

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн  
Олон Улсын Стандартын Зөвлөл

International Public Sector Accounting  
Standards Board®



# УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН ТУНХАГЛАЛУУДЫН ГАРЫН АВЛАГА

## УСНББОУС

БОТЬ II  
2021 он

International Federation of Accountants®  
Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо  
529 тавдугаар өргөн чөлөө  
Нью Йорк, Нью Йорк 10017 АНУ

Энэхүү бүтээлийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ) (International Federation of Accountants (IFAC®))-ноос хэвлэн гаргасан. ДНБХ-ны эрхэм зорилго нь өндөр чанартай, олон улсын стандартын хөгжилд дэмжлэг үзүүлэх, эдгээр стандартын мөрдөлт ба хэрэгжүүлэлтийг хөхүүлэн дэмжих, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн эрх ашгийн асуудлуудын талаар саналаа илэрхийлэх замаар нийтийн эрх ашигт үйлчлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг хөгжүүлэн бэхжүүлэх явдал юм.

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards), Саналын Төсөл (Exposure Drafts), Зөвлөлдөх Баримт Бичиг (Consultation Papers), Санал Болгосон Практик Удирдамж (Recommended Practice Guidelines) болон УСНББОУСЗ (IPSASB)-ийн бусад хэвлэлүүдийг ДНБХ (IFAC)-оос хэвлэн гаргасан бөгөөд түүний зохиогчийн эрхэд хамаарна.

Энэхүү хэвлэлд тусгагдсан материалуудад итгэл үзүүлэн үйлдэл хийсэн эсвэл үйлдлээ больсоны улмаас хэн нэгэнд хохирол учирсан тохиолдолд хохирол нь хайнга байдал буюу бусад шалтгаанаар үүссэн эсэхээс үл хамааран УСНББОУСЗ (IPSASB) болон ДНБХ (IFAC) нь уг хохирлын хувьд хариуцлага хүлээхгүй болно.

‘Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл’ (International Public Sector Accounting Standards Board), ‘Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт’ (International Public Sector Accounting Standards), ‘Санал Болгосон Практик Удирдамж’ (Recommended Practice Guidelines), ‘Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо’ (International Federation of Accountants), ‘УСНББОУСЗ’ (IPSASB), ‘УСНББОУС’ (IPSAS), ‘СБПУ’ (RPG), ‘ДНБХ’ (IFAC), ‘УСНББОУСЗ’ (IPSASB) гэсэн лого, ‘ДНБХ’ (IFAC) гэсэн лого нь АНУ болон бусад улс орнууд дахь ДНБХ (IFAC)-ны худалдааны тэмдэг буюу бүртгэгдсэн худалдааны тэмдэг ба үйлчилгээний тэмдэг юм.

Зохиогчийн эрх © 2018 оны 9 дүгээр сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ) (International Federation of Accountants (IFAC)). Бүх эрх хамгаалагдсан. Зөвхөн хувьдаа, худалдаа арилжааны бус зорилгоор ашиглахаас бусад тохиолдолд энэхүү баримт бичгийг хувиран олшруулах, хадгалах, шилжүүлэх буюу бусад адилтгах байдлаар ашиглахын тулд ДНБХ (IFAC)-ноос бичгэн зөвшөөрөл авах шаардлагатай.

Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны (International Federation of Accountants) дэргэдэх Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (International Public Sector Accounting Standards Board)-өөс баталсан, 2018 оны 9 дүгээр сард Англи хэл дээр хэвлэн гаргасан энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards) 2018-ыг Сангийн яам 2019 онд Монгол хэл дээр орчуулах ажлыг гүйцэтгэж, ДНБХ (IFAC)-ны зөвшөөрөлтэйгээр дахин хэвлэсэн болно. Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards) 2018-ын орчуулгын үйл явцыг ДНБХ (IFAC)-ноос хянасан бөгөөд орчуулгыг “Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (International Federation of Accountants)-ны Хэвлэл Бүтээлүүдийг Орчуулах Бодлого”-ын дагуу гүйцэтгэсэн. ДНБХ (IFAC)-ноос Англи хэл дээр хэвлэн гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards) 2018-ын дээрх текстүүд нь батлагдсан хувь нь байна. ДНБХ (IFAC) нь орчуулгын үнэн зөв, бүрэн бүтэн байдал, эсвэл үүнээс үүдэн гарч болзошгүй үйл явдалд хариуцлага хүлээхгүй болно.

ДНБХ (IFAC)-ноос Англи хэл дээр хэвлэн гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards) © 2018. Бүх эрх хамгаалагдсан.

ДНБХ (IFAC)-ноос хэвлэн гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards) © 2018-ын Монгол хэл дээрх орчуулга. Бүх эрх хамгаалагдсан.

Албан ёсны гарчиг: *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Тунхаглалуудын Гарын Авлага, 2018 оны хэвлэл, ISBN: 978-1-60815-362-6*

Энэхүү баримт бичгийг хувиран олшруулах, хадгалах, шилжүүлэх буюу бусад адилтгах байдлаар ашиглахын тулд [permission@ifac.org](mailto:permission@ifac.org) хаягаар хандана уу.



ДНБХ-ноос хэвлэв

**УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ  
БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ**

**IPSAS®**

ЭНЭ ХУУДСЫГ ЗОРИУД ХООСОН ҮЛДЭЭВ

# АГУУЛГА

## БОТЬ II

Хуудас

### Боть II-ын агуулгын хүснэгт 1407

УСНББОУС 30-Санхүүгийн хэрэглүүр: тодруулга .....	1409
УСНББОУС 31-Биет бус хөрөнгө .....	1467
УСНББОУС 32-Үйлчилгээний концессын хэлцэл: эрх бүхий этгээд .....	1530
УСНББОУС 33-Аккруэл суурьт (УСНББОУС)-ыг анх удаа мөрдөх .....	1596
УСНББОУС 34-Тусдаа санхүүгийн тайлан .....	1724
УСНББОУС 35-Нэгтгэсэн санхүүгийн тайлан .....	1742
УСНББОУС 36-Хараат байгууллага ба хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт .....	1867
УСНББОУС 37-Хамтын хэлэлцээр .....	1894
УСНББОУС 38-Бусад байгууллагууд дахь хувь оролцооны тодруулга .....	1947
УСНББОУС 39-Ажилтны тэтгэмж .....	1986
УСНББОУС 40-Улсын секторын нэгдэл .....	2054
Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурьт улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын танилцуулга .....	2299
Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт: нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурьт санхүүгийн тайлагнал .....	2300
Мөнгөн суурьт УСНББОУС-нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурьт санхүүгийн тайлагнал-2017 онд гаргасан .....	2434
Санал болгосон практик удирдамжийн танилцуулга .....	2565
Санал болгосон практик удирдамж СБПУ 1-3 .....	2566
УСНББОУС 1-40 ийн тодорхойлсон нэр томъёоны тайлбар толь .....	2651
2018 оны 01 дүгээр сарын 31-ний байдлаар гаргасан байгаа аккруэл суурьт УСНББОУС-ууд .....	2725

ЭНЭ ХУУДСЫГ ЗОРИУД ХООСОН ҮЛДЭЭВ

## УСНББОУС 30–САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) 7, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-аас үндсэндээ бэлтгэсэн болно. СТОУС 7-гоос авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.



## УСНББОУС 30-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

### УСНББОУС-ЫН ТҮҮХ

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга-ыг 2010 оны 01 дүгээр сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 30-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 38, Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)

### УСНББОУС 30-ЫН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ПАРАГРАФУУДЫН ХҮСНЭГТ

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
3	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
6	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
7	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
52А	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
52Б	Шинэ	УСНББОУС 38, 2015 оны 01-р сар УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
52В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

52Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
52Д	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
53	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
МЗУ6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 38, 2015 оны 01-р сар

2010 оны 01 дүгээр сар

## УСНББОУС 30–САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

### АГУУЛГА

	Параграф
Зорилго	1-2
Цар хүрээ	3-7
Тодорхойлолт	8
Санхүүгийн хэрэглүүрийн ангиуд ба тодруулгын түвшин	9
Санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрийн үзүүлэх ач холбогдол	10-37
Санхүүгийн байдлын тайлан	11-23
Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн ангилал	11
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр	12-14
Дахин ангилал	15-16
Үл хүлээн зөвшөөрөлт	17
Барьцаа	18-19
Зээлийн гарзын хасагдуулгын данс	20
Дагалдах олон үүсмэл хэрэглүүр бүхий нийлмэл санхүүгийн хэрэглүүр	21
Үл биелүүлэлт ба зөрчил	22-23
Санхүүгийн үр дүнгийн тайлан	24
Орлого, зардал, олз, гарзын зүйлс	24
Бусад тодруулга	25-37
Нягтлан бодох бүртгэлийн бодлого	25
Хейжийн нягтлан бодох бүртгэл	26-28
Бодит үнэ цэнэ	29-36
Хөнгөлөлттэй зээл	37
Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдлийн шинж төрөл ба хэмжээ	38-49
Чанарын шинжтэй тодруулга	40
Тоон шинжтэй тодруулга	41-49
Зээлийн эрсдэл	43-45
Хугацаа өнгөрсөн буюу үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө	44
Олж эзэмшсэн барьцаа болон зээлийн бусад сайжруулалт	45
Төлбөрийн чадварын эрсдэл	46
Зах зээлийн эрсдэл	47-49
Мэдрэмжийн шинжилгээ	47-48
Зах зээлийн эрсдлийн бусад тодруулга	49
Хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилт	50-53
УСНББОУС 15 (2001 он)-аас татгалзах ба орлуулах	54
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

Дүгнэлтийн үндэслэл  
Хэрэгжүүлэх заавар удирдамж  
СТОУС 7-той харьцуулалт

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ыг 1-54-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 30-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэхүү Стандартын зорилго нь дараах зүйлсийг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгох байдлаар өөрсдийн санхүүгийн тайландаа тодруулга хийхийг байгууллагуудаас шаардахад оршино. Үүнд:
  - (а) Тухайн байгууллагын санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрийн үзүүлэх ач холбогдол; ба
  - (б) Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх бөгөөд байгууллагад тухайн тайлант үеийн туршид болон тайлант үеийн эцэст учрах эрсдлийн шинж төрөл ба хэмжээ, түүнчлэн тэдгээр эрсдлийг уг байгууллага хэрхэн удирдан зохицуулдаг эсэх.
2. Энэхүү Стандарт дахь зарчмууд нь УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга* болон УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-т заасан санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, хэмжих, толилуулах зарчмуудын нэмэлт гүйцээлт болно.

## Цар хүрээ

3. **Бүх байгууллагууд нь доор дурдсанаас бусад бүх төрлийн санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:**
  - (а) **УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ын дагуу тайлагнадаг хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо.** Гэвч зарим тохиолдолд УСНББОУС 34, УСНББОУС 35, УСНББОУС 36 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог УСНББОУС 29-ийн дагуу тайлагнахыг байгууллагаас шаарддаг буюу зөвшөөрдөг. Ийм тохиолдолд байгууллага нь энэ Стандартын шаардлагуудыг мөрдөнө. Хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоотой холбоотой үүсмэл хэрэглүүр нь УСНББОУС 28-д заасан тухайн байгууллагын өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахаас бусад тохиолдолд байгууллагууд нь тэрхүү үүсмэл хэрэглүүрт мөн энэ Стандартыг дагаж мөрдөнө.
  - (б) **УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг мөрдөх ажилтны тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу хүлээх ажил олгогчийн эрх ба үүрэг.**
  - (в) **Даатгалын гэрээний дагуу үүсэх эрх ба үүрэг.** Гэхдээ энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөнө:

- (i) хэрэв УСНББОУС 29 нь даатгалын гэрээг дагалдан гардаг үүсмэл хэрэглүүрийг тусдаа тайлагнахыг байгууллагаас шаарддаг бол тэдгээр үүсмэл хэрэглүүрт;
- (ii) Санхүүгийн баталгааны гэрээ гаргагч нь уг гэрээг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ УСНББОУС 29-ийг мөрддөг бол тэрхүү санхүүгийн баталгааны гэрээ гаргагчийн хувьд энэ Стандартыг мөрдөнө; харин гаргагч нь даатгалын гэрээг хүлээн зөвшөөрч, хэмжихдээ тухайн даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх сонголт хийсэн бол тэдгээр стандартаа мөрдөнө.

Дээрх (i) ба (ii)-д дурдсанаас гадна байгууллага нь санхүүгийн эрсдлийн шилжүүлэлтийг агуулсан даатгалын гэрээнд энэ Стандартыг мөрдөж болох юм.

- (г) УСНББОУС 29-ийг мөрддөг ба түүний 4-6-р параграфын цар хүрээнд хамаарах гэрээнүүдээс бусад бөгөөд хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрддөг хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээнээс үүссэн санхүүгийн хэрэглүүр, гэрээ ба үүрэг.
  - (д) УСНББОУС 28-ын 15, 16-р параграфууд эсвэл 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилах шаардлагатай санхүүгийн хэрэглүүр.
4. Хүлээн зөвшөөрсөн болон хүлээн зөвшөөрөөгүй санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө. Хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүр нь УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг агуулсан байна. Харин хүлээн зөвшөөрөөгүй санхүүгийн хэрэглүүр нь УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй боловч энэ Стандартын цар хүрээнд хамаарах зарим санхүүгийн хэрэглүүрийг агуулсан байна.
5. УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээний хувьд энэ Стандартыг мөрдөнө (УСНББОУС 29-ийн 4-6-р параграфыг үзнэ үү).

6. [Хассан]

7. [Хассан]

## Тодорхойлолт

8. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Зээлийн эрсдэл** гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн оролцогч нэг тал нь үүргээ биелүүлээгүйн улмаас оролцогч нөгөө талдаа санхүүгийн хохирол учруулах эрсдэл юм.

**Валютын эрсдэл** гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл юм.

**Хүүний түвшний эрсдэл** гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтийн улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл юм.

**Төлбөрийн чадварын эрсдэл** гэдэг нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгснөөр барагдуулах санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргийг тухайн байгууллага биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм.

**Зээлийн өглөг** гэдэг нь зээлийн хэвийн нөхцөл бүхий богино хугацаат худалдааны өглөгөөс бусад санхүүгийн өр төлбөр юм.

**Зах зээлийн эрсдэл** гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь зах зээлийн үнийн өөрчлөлтийн улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл юм. Зах зээлийн эрсдэл нь валютын эрсдэл, хүүний түвшний эрсдэл, үнийн бусад эрсдэл гэсэн гурван төрлийн эрсдлээс бүрддэг.

**Үнийн бусад эрсдэл** гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь зах зээлийн үнийн өөрчлөлтийн (хүүний түвшний эрсдэл буюу валютын эрсдлээс үүссэнээс бусад өөрчлөлтийн) улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл бөгөөд тэдгээр өөрчлөлт нь тухайн санхүүгийн хэрэглүүр буюу түүний гаргагчид тусгайлан хамаарах хүчин зүйлсээс эсвэл зах зээлд арилжаалагдаж буй ижил төсөөтэй бүх санхүүгийн хэрэглүүрт нөлөөлөх хүчин зүйлсээс шалтгаалсан эсэхээс үл хамаарна.

Гэрээний дагуу төлөх ёстой хугацаа болсон төлбөрийг нөгөө тал нь барагдуулаагүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн **хугацаа өнгөрсөн** гэнэ.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

## **Санхүүгийн хэрэглүүрийн ангиуд ба тодруулгын түвшин**

9. Энэ Стандарт нь санхүүгийн хэрэглүүрийн ангиар тодруулга хийхийг шаарддаг тохиолдолд байгууллага нь тухайн тодруулах мэдээллийн шинж төрөлд тохирох бөгөөд тэдгээр санхүүгийн хэрэглүүрийн шинж чанарыг харгалзсан ангиудаар санхүүгийн хэрэглүүрүүдийг бүлэглэнэ. Байгууллага нь санхүүгийн байдлын тайланд толилуулсан тухайн мөрийн зүйлсийг задлан тохируулах боломж олгохын тулд хангалттай мэдээллийг бүрдүүлж өгнө.



## **Санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрийн үзүүлэх ач холбогдол**

10. Байгууллага нь түүний санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрүүдийн үзүүлэх ач холбогдлыг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна.

### **Санхүүгийн байдлын тайлан**

*Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн ангилал*

11. УСНББОУС 29-д тодорхойлсон, дараах ангилал тус бүрийн дансны үнийг санхүүгийн байдлын тайланд эсвэл тодруулгад нэмж тодруулна:
- (a) Доорх байдлаар тусад нь харуулсан бөгөөд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө: (i) анх хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө, ба (ii) УСНББОУС 29-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан санхүүгийн хөрөнгө;
  - (б) Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;
  - (в) Зээл ба авлага;
  - (г) Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө;
  - (д) Доорх байдлаар тусад нь харуулсан бөгөөд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр: (i) анх хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн өр төлбөр, ба (ii) УСНББОУС 29-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан санхүүгийн өр төлбөр;
  - (е) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөр.

*Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр*

12. Хэрэв байгууллага нь зээл буюу авлагыг (эсвэл зээлүүд буюу авлагуудын бүлгийг) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бол тухайн байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (a) Тухайн тайлант үеийн эцэс дэх зээл буюу авлагын (эсвэл зээлүүд буюу авлагуудын бүлгийн) зээлийн эрсдлийн хамгийн их хэмжээ (43(a) параграфыг үзнэ үү);
  - (б) Холбогдох аливаа зээлийн үүсмэл хэрэглүүр буюу ижил төсөөтэй хэрэглүүрээр уг зээлийн эрсдлийн хамгийн их хэмжээг бууруулах дүн;
  - (в) Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох бөгөөд доорх хоёр хувилбарын аль нэгээр тодорхойлсон, уг

зээл буюу авлагын (эсвэл зээлүүд буюу авлагуудын бүлгийн) бодит үнэ цэнэд тухайн тайлант үеийн туршид болон хуримтлагдсан байдлаар гарсан өөрчлөлтийн дүн:

- (i) зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг тухайн зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд хамааруулж болохгүй түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүн байдлаар; эсвэл
- (ii) тухайн хөрөнгийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг илүү үнэн зөв илэрхийлнэ гэж уг байгууллагын найдаж буй өөр хувилбар аргыг ашигласнаар.

Зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг, зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд ажиглаж болох (бенчмарк) хүүний түвшин, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индексийн өөрчлөлтүүд хамаарна.

- (г) Холбогдох аливаа зээлийн үүсмэл хэрэглүүр буюу ижил төсөөтэй хэрэглүүрийн бодит үнэ цэнэд уг зээл буюу авлагыг ингэж ангилснаас хойш тухайн тайлант үеийн туршид болон хуримтлагдсан байдлаар гарсан өөрчлөлтийн дүн.

13. Хэрэв байгууллага нь УСНББОУС 29-ийн 10-р параграфын дагуу санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бол уг байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (a) Санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох бөгөөд доорх хоёр хувилбарын аль нэгээр тодорхойлсон, уг санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэд тухайн тайлант үеийн туршид болон хуримтлагдсан байдлаар гарсан өөрчлөлтийн дүн:
  - (i) зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг тухайн зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд хамааруулж болохгүй түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүн байдлаар (Хавсралт А-гийн МЗУ4-р параграфыг үзнэ үү); эсвэл
  - (ii) тухайн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг илүү үнэн зөв илэрхийлнэ гэж уг байгууллагын найдаж буй өөр хувилбар аргыг ашигласнаар.

Зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг, зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд бенчмарк хүүний түвшин, өөр байгууллагын санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индексийн өөрчлөлтүүд хамаарна. Нэгжтэй уялдах шинж бүхий гэрээний хувьд зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд тухайн холбогдох дотоодын буюу гаднын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэлийн өөрчлөлтүүд хамаардаг.

- (б) Санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба дуусвар болох өдөр уг өрийн хэрэглүүрийн эзэмшигчид гэрээний дагуу тухайн байгууллагын төлөх шаардлагатай дүн хоорондох зөрүү.

14. Байгууллага нь мөн дараах зүйлсийг тодруулна:

- (а) 12(в) ба 13(а) параграфуудад заасан шаардлагуудыг даган мөрдөхийн тулд ашигласан аргууд.
- (б) 12(в) эсвэл 13(а) параграфуудад заасан шаардлагуудыг даган мөрдөхийн тулд түүний хийсэн тодруулгууд нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг үнэн зөв толилуулаагүй гэж уг байгууллага нь үзэж байвал ийм дүгнэлтэнд хүрэх болсон шалтгаан ба хамааралтай гэж түүний найдаж буй хүчин зүйлс.

*Дахин ангилал*

15. Хэрэв байгууллага нь дараах аль нэг байдлаар хэмжсэнээр санхүүгийн хөрөнгийг (УСНББОУС 29-ийн 60-63-р параграфын дагуу) дахин ангилсан бол тухайн байгууллага нь ангилал тус бүрийн хувьд түүнд оруулсан ба түүнээс гарган дахин ангилсан дүн, түүнчлэн тийм дахин ангиллын учир шалтгааныг тодруулна:

- (а) Бодит үнэ цэнээр биш, харин өртөг буюу хорогдуулсан өртгөөр хэмжсэн; эсвэл
- (б) Өртөг буюу хорогдуулсан өртгөөр биш, харин бодит үнэ цэнээр хэмжсэн;

16. Хэрэв байгууллага нь УСНББОУС 29-ийн 55 буюу 57-р параграфын дагуу санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллаас хасаж, дахин ангилсан, эсвэл УСНББОУС 29-ийн 58-р параграфын дагуу борлуулах боломжтой гэсэн ангиллаас хасаж, дахин ангилсан бол тухайн байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Ангилал тус бүрийн хувьд түүнд оруулсан ба түүнээс гарган дахин ангилсан дүн;
- (б) Үл хүлээн зөвшөөрөх хүртэлх тайлант үе тус бүрийн хувьд, одоогийн болон өмнөх тайлант үеүдэд дахин ангилсан бүх санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнэ ба бодит үнэ цэнэ;
- (в) Санхүүгийн хөрөнгийг УСНББОУС 29-ийн 55-р параграфын дагуу дахин ангилсан бол ийм цөөн ховор тохиолдол, түүнчлэн уг тохиолдол цөөн ховор гэдгийг илэрхийлэх баримт материал болон нөхцөл байдлууд;
- (г) Санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан тайлант үеийн хувьд тэрхүү тайлант үед болон өмнөх тайлант үед ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн уг санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн олз буюу гарз;

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

- (д) Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх хүртэлх түүний дахин ангиллын дараах тайлант үе тус бүрийн (үүн дотроо, санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан тайлант үеийн) хувьд, хэрэв уг санхүүгийн хөрөнгийг дахин ангилаагүй бол ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх байсан бодит үнэ цэнийн олз буюу гарз, түүнчлэн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн олз, гарз, орлого, зардал;
- (е) Санхүүгийн хөрөнгийн дахин ангиллын өдрөөр уг байгууллагын нөхөхөөр хүлээж буй мөнгөн гүйлгээний тооцоолсон дүн ба үр ашигт хүүний түвшин.

### *Үл хүлээн зөвшөөрөлт*

17. Санхүүгийн хөрөнгийн бүх буюу зарим хэсэг нь үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах тийм шилжүүлэлтээр тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлж болох юм (УСНББОУС 29-ийн 17-39-р параграфыг үзнэ үү). Байгууллага нь ийм санхүүгийн хөрөнгийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:
- (а) Хөрөнгийн шинж төрөл;
  - (б) Байгууллага нь өртсөн хэвээр байх өмчлөлийн эрсдэл ба урамшууллын шинж төрөл;
  - (в) Байгууллага нь бүх хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байх тохиолдолд тэдгээр хөрөнгүүд болон холбогдох өр төлбөрүүдийн дансны үнэ;
  - (г) Байгууллага нь хөрөнгийг өөрийн цаашдын оролцооны хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн хэвээр байх тохиолдолд уг анхны хөрөнгүүдийн нийт дансны үнэ, тухайн байгууллага хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хөрөнгүүдийн дүн болон холбогдох өр төлбөрүүдийн дансны үнэ.

### *Барьцаа*

18. Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Өр төлбөр буюу болзошгүй өр төлбөрийн баталгаа болгон барьцаалсан санхүүгийн хөрөнгийн дансны үнэ, үүн дотроо УСНББОУС 29-ийн 39(а) параграфын дагуу дахин ангилсан дүн; ба
  - (б) Түүний барьцаатай холбоотой нөхцөл, болзол.
19. Байгууллага нь (санхүүгийн буюу санхүүгийн бус хөрөнгийн) барьцаа хөрөнгийг эзэмшиж байгаа бөгөөд үл биелүүлэлтийн нөхцөл байдал арилсан ч гэсэн тэрхүү барьцаа хөрөнгийг борлуулах буюу бусдад дахин барьцаалахыг уг хөрөнгийн эзэн зөвшөөрсөн тохиолдолд тухайн байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Эзэмшиж байгаа барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ;

- (б) Борлуулсан буюу бусдад дахин барьцаалсан ийм аливаа барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ, түүнчлэн тухайн байгууллага нь түүнийг буцаан өгөх үүрэгтэй эсэх; ба
- (в) Барьцаа хөрөнгийг ашиглахтай холбоотой нөхцөл, болзол.

*Зээлийн гарзын хасагдуулгын данс*

20. Зээлийн гарзын улмаас санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан бөгөөд байгууллага нь хөрөнгийн дансны үнийг шууд бууруулахын оронд үнэн цэнийн бууралтыг тусдаа дансанд бүртгэдэг (жишээлбэл; тус тусын үнэ цэнийн бууралтыг бүртгэхийн тулд хасагдуулгын данс ашигладаг эсвэл хөрөнгүүдийн нийт үнэ цэнийн бууралтыг бүртгэхийн тулд үүнтэй адилтгах дансыг ашигладаг) тохиолдолд уг байгууллага нь санхүүгийн хөрөнгийн анги тус бүрийн хувьд тухайн тайлант үеийн туршид тэрхүү дансанд орсон өөрчлөлтийн тохируулгыг тодруулна.

*Дагалдах олон үүсмэл хэрэглүүр бүхий нийлмэл санхүүгийн хэрэглүүр*

21. Байгууллага нь өр төлбөрийн болон өмчийн бүрэлдэхүүн хэсгийн аль алиныг агуулсан хэрэглүүрийг гаргасан (УСНББОУС 28-ын 33-р параграфыг үзнэ үү) бөгөөд уг хэрэглүүр нь дагалдах олон үүсмэл хэрэглүүртэй (дуудах эрхтэй хөрвөх өрийн хэрэглүүр гэх мэт) ба тэдгээрийн үнэ цэнэ нь бие биенээсээ хамааралтай бол уг байгууллага нь тэдгээр шинжүүдийн оршин байдлыг тодруулна.

*Үл биелүүлэлт ба зөрчил*

22. Тухайн тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрсөн зээлийн өглөгийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Тухайн тайлант үеийн туршид тэрхүү зээлийн үндсэн дүн, хүү, эргэлтээс гаргах сан, зээлийг эргэлтээс гаргах нөхцлийн хувьд үүссэн аливаа үл биелүүлэлтийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (б) Тайлант үеийн эцэст үл биелүүлсэн зээлийн өглөгийн дансны үнэ;
  - (в) Санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө уг үл биелүүлэлтийг засварласан эсвэл зээлийн өглөгийн нөхцлийг дахин хэлэлцэн тохирсон эсэх.
23. Тухайн тайлант үеийн туршид 22-р параграфт дурдснаас бусад байдлаар зээлийн гэрээний нөхцлийг зөрчсөн бөгөөд ийм зөрчлийн улмаас зээлдүүлэгч нь зээлийг хурдавчлан буцаан төлөхийг шаардах боломжтой болсон тохиолдолд (тухайн тайлант үеийн эцэст буюу түүнээс өмнө уг зөрчлийг засварласан эсвэл зээлийн нөхцлийг дахин хэлэлцэн тохирсноос бусад тохиолдолд) байгууллага нь 22-р параграфтаар шаардсантай адил мэдээллийг тодруулна.

## Санхүүгийн үр дүнгийн тайлан

*Орлого, зардал, олз, гарзын зүйлс*

24. Байгууллага нь орлого, зардал, олз, гарзын дараах зүйлсийг санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл тодруулгад тусгана:
- (a) Доорх зүйлсийн цэвэр олз эсвэл цэвэр гарз:
    - (i) Анх хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн хувьд тус тусад нь харуулсан ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн цэвэр олз эсвэл цэвэр гарз болон УСНББОУС 29-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн цэвэр олз эсвэл цэвэр гарз;
    - (ii) Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн хувьд тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн олз, гарзын дүн ба цэвэр хөрөнгө/өмчөөс дахин ангилж, тайлант үеийн ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрсөн дүнг тус тусад нь харуулах;
    - (iii) Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;
    - (iv) Зээл ба авлага; ба
    - (v) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөр.
  - (б) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит цэнээр хэмжээгүй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн нийт хүүний орлого ба нийт хүүний зардал (үр ашигт хүүний аргыг ашиглан тооцоолсон);
  - (в) Дараах зүйлсээс үүссэн хураамжийн орлого ба зардал (үр ашигт хүүний түвшнийг тодорхойлоход оруулж тооцсон дүнгээс бусад):
    - (i) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээгүй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр;
    - (ii) Хувь хүмүүс, итгэлцлийн сан, тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн хөтөлбөр болон бусад байгууллагын нэрийн өмнөөс хөрөнгийг эзэмших буюу хөрөнгө оруулалт хийх үр дүн бүхий итгэлцлийн сангийн болон бусад итгэмжлэгдсэн үйл ажиллагаа.
  - (г) Үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд УСНББОУС 29-ийн МЗУ126-р параграфын дагуу хуримтлуулсан хүүний орлого; ба
  - (д) Санхүүгийн хөрөнгийн анги тус бүрд хамаарах үнэ цэнийн бууралтын аливаа гарзын дүн.

## Бусад тодруулга

### *Нягтлан бодох бүртгэлийн бодлого*

25. УСНББОУС 1-ийн 132-р параграфын дагуу байгууллага нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ ашигласан хэмжилтийн суурь (буюу сууриуд) болон тухайн санхүүгийн тайланг ойлгоход хамааралтай, бусад ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын тоймд тусган тодруулна.

### *Хейжийн нягтлан бодох бүртгэл*

26. Байгууллага нь УСНББОУС 29-д дурдсан хейжийн төрөл тус бүрийн (өөрөөр хэлбэл, бодит үнэ цэнийн хейж, мөнгөн гүйлгээний хейж, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж) хувьд дараах зүйлсийг тус тусад нь тодруулна:

- (а) Хейжийн төрөл тус бүрийн тайлбар тодорхойлолт;
- (б) Хейжийн хэрэглүүр гэж сонгосон санхүүгийн хэрэглүүрийн тайлбар тодорхойлолт ба тухайн тайлант үеийн эцэс дэх тэдгээрийн бодит үнэ цэнэ; ба
- (в) Хейж хийж буй эрсдлийн шинж төрөл;

27. Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Мөнгөн гүйлгээнүүд гарч тохиолдохоор хүлээгдэж буй тайлант үеүд болон ашиг, алдагдалд тэдгээрийн нөлөө үзүүлэхээр хүлээгдэж буй тайлант үеүд;
- (б) Өмнө нь хейжийн нягтлан бодох бүртгэлийг ашиглаж байсан боловч цаашид гарч тохиолдохоор хүлээгдэхээргүй болсон аливаа урьдчилан таамагласан ажил гүйлгээний тайлбар тодорхойлолт;
- (в) Тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн дүн;
- (г) Цэвэр хөрөнгө/өмчөөс гаргаж дахин ангилсан ба тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тусган оруулсан дүн, үүнд санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйл нэг бүрд тусган оруулсан дүнг харуулна; ба
- (д) Олж эзэмшилт буюу гарч тохиолдолт нь хейж хийсэн өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ байх тийм санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөрийн анхны өртөг болон бусад дансны үнэд тусган оруулж, тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчөөс хассан дүн.

28. Байгууллага нь дараах зүйлсийг тус тусад нь тодруулна:

- (а) Бодит үнэ цэнийн хейжийн хувьд доорх зүйлсийн олз буюу гарз:

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

- (i) Хейжийн хэрэглүүрийн; ба
  - (ii) Уг хейж хийсэн эрсдэлд хамааруулж болох хейжийн зүйлийн.
- (б) Мөнгөн гүйлгээний хейжээс үүссэн ба ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үр дүнгүй байдал; ба
- (в) Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжээс үүссэн ба ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үр дүнгүй байдал.

### *Бодит үнэ цэнэ*

29. 35-р параграфт зааснаас бусад тохиолдолд, санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн анги тус бүрийн хувьд (9-р параграфыг үзнэ үү), байгууллага нь хөрөнгө ба өр төлбөрийн тухайн ангийн бодит үнэ цэнийг түүний дансны үнэтэй зэрэгцүүлэх боломжтой байдлаар тодруулна.
30. Бодит үнэ цэнийг тодруулахдаа, байгууллага нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг ангиудад бүлэглэх бөгөөд тэдгээрийн дансны үнийг санхүүгийн байдлын тайланд харилцан суутгаж, цэвэр дүнгээр тусгадаг зөвхөн тэр хэмжээгээр тэдгээрийн бодит үнэ цэнийг харилцан суутгаж, цэвэр дүнгээр тусгана.
31. Санхүүгийн хэрэглүүрийн анги тус бүрийн хувьд байгууллага нь тэдгээр санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн анги тус бүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох аргууд болон хэрэв үнэлгээний арга зүй ашигласан бол хийсэн таамаглалуудыг тодруулна. Жишээлбэл; хэрэв хамааралтай бол байгууллага нь урьдчилсан төлбөрийн хувь хэмжээ, тооцоолсон зээлийн гарзын хувь хэмжээ, хүүний түвшин, дискаунтын хувь хэмжээтэй холбоотой таамаглалуудын талаархи мэдээллийг тодруулна. Үнэлгээний арга зүйд өөрчлөлт орсон бол байгууллага нь тэрхүү өөрчлөлт, түүнчлэн өөрчлөлт хийсэн шалтгааныг тодруулна.
32. 33-р параграфтаар шаардсан тодруулгыг хийхийн тулд байгууллага нь бодит үнэ цэнийн хэмжилтийг хийхэд ашигласан орцуудын ач холбогдлыг тусгах бодит үнэ цэнийн шатлалыг харгалзсанаар бодит үнэ цэнийн хэмжилтүүдийг ангилна. Бодит үнэ цэнийн шатлал нь дараах түвшингүүдтэй байдаг:
- (а) Адилтгах хөрөнгө буюу өр төлбөрийн идэвхитэй зах зээлийн (залруулаагүй) жишиг үнэ (Түвшин 1);
  - (б) Тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд шууд (өөрөөр хэлбэл, үнэ байдлаар) эсвэл шууд бусаар (өөрөөр хэлбэл, үнээс тооцсоноор) ажиглах боломжтой бөгөөд Түвшин 1-д хамаарсан жишиг үнээс бусад орц (Түвшин 2); ба
  - (в) Тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд зах зээлийн ажиглаж болох мэдээнд үндэслээгүй орц (ажиглах боломжгүй орц) (Түвшин 3).

Бодит үнэ цэнийн хэмжилтийг бүхэлд нь ангилах бодит үнэ цэнийн шатлал дахь тухайн нэг түвшинг нийт бодит үнэ цэнийн хэмжилтэнд ач



холбогдолтой байх хамгийн доод түвшний орцод үндэслэн тодорхойлно. Энэ зорилгоор орцын ач холбогдлыг нийт бодит үнэ цэнийн хэмжилттэй харьцуулж үнэлнэ. Хэрэв бодит үнэ цэнийн хэмжилт нь ажиглах боломжгүй орцуудад үндэслэсэн мэдэгдэхүйц залруулгыг шаардах тийм ажиглаж болох орцуудыг ашигладаг бол уг хэмжилт нь Түвшин 3-ын хэмжилт болно. Нийт бодит үнэ цэнийн хэмжилтэнд тухайн нэг орцын үзүүлэх ач холбогдлыг үнэлэх нь тэрхүү хөрөнгө буюу өр төлбөрт тусгайлан хамаарах хүчин зүйлсийг харгалзсан шүүн тунгаалт хийхийг шаардана.

33. Санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн хэмжилтүүдийн хувьд байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн анги тус бүрээр дараах зүйлсийг тодруулна:

- (a) Тухайн бодит үнэ цэнийн хэмжилтийг бүхэлд нь хамааруулан ангилж уг бодит үнэ цэнийн шатлалын түвшин, энд 32-р параграфт тодорхойлсон түвшингүүдийн дагуу бодит үнэ цэнийн хэмжилтүүдийг салган зааглах;
- (б) Бодит үнэ цэнийн шатлалын Түвшин 1 ба Түвшин 2-ын хооронд хийгдсэн аливаа мэдэгдэхүйц ач холбогдолтой шилжүүлэлтүүд ба тэдгээр шилжүүлэлтийг хийсэн учир шалтгаан. Түвшин бүрд оруулсан шилжүүлэлтийг тэдгээр түвшин бүрээс гаргасан шилжүүлэлтээс тусад нь авч үзэж, тодруулна. Энэ зорилгоор ач холбогдлыг ашиг алдагдал, нийт хөрөнгө эсвэл нийт өр төлбөртэй харьцуулан шүүн тунгаана.
- (в) Түвшин 3 дахь бодит үнэ цэнийн хэмжилтийн хувьд, эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдэл хүртэлх тохируулгын тайлан, үүнд дараах зүйлсэд хамааруулан ангилж болох бөгөөд тухайн тайлант үеийн туршид гарсан өөрчлөлтүүдийг тусад нь тодруулна:
  - (i) Тухайн тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн нийт олз, гарз ба тэдгээр олз, гарзыг санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулсан мөрийн зүйлсийн талаархи тайлбар тодорхойлолт;
  - (ii) Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн нийт олз буюу гарз;
  - (iii) Худалдан авалт, борлуулалт, гаргалт, барагдуулалт (эдгээр өөрчлөлтийн төрөл нэг бүрийг тусад нь тодруулах); ба
  - (iv) Түвшин 3-д оруулсан эсвэл түүнээс гаргасан аливаа шилжүүлэлт (жишээлбэл; шилжүүлэлт нь зах зээлийн мэдээний ажиглах боломжтой байдалд гарсан өөрчлөлтөнд хамаарах эсэх) ба ийм шилжүүлэлт хийсэн учир шалтгаан. Түвшин 3-д оруулсан шилжүүлэлтийг тэрхүү түвшнээс гаргасан шилжүүлэлтээс тусад нь авч үзэж, тодруулна.
- (г) Дээрх (в)-гийн (i)-д дурдсан тухайн тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн нийт олз, гарзаас уг тайлант үеийн эцэст эзэмшиж байгаа тэдгээр хөрөнгө, өр төлбөртэй холбоотой олз, гарзад хамаарах хэсэг ба тэрхүү олз, гарзыг санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулсан мөрийн зүйлсийн тайлбар тодорхойлолт.

- (д) Түвшин 3 дахь бодит үнэ цэнийн хэмжилтийн хувьд, ул үндэслэлтэйгээр боломжтой хувилбар таамаглалуудын нэг буюу хэд хэдэн орцуудыг өөрчлөх нь бодит үнэ цэнийг мэдэгдэхүйц өөрчлөх бол байгууллага нь энэ тухай илэрийлэх ба тэдгээр өөрчлөлтийн үр нөлөөг тодруулна. Ул үндэслэлтэйгээр боломжтой хувилбар таамаглалын өөрчлөлтийн үр нөлөөг хэрхэн тооцоолсоноо уг байгууллага нь тодруулна. Энэ зорилгоор ач холбогдлыг ашиг алдагдал, нийт хөрөнгө эсвэл нийт өр төлбөртэй, харин бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн бол нийт өмчтэй харьцуулан шүүн тунгаана.

Өөр хэлбэр загвар илүү тохиромжтой байхаас бусад тохиолдолд байгууллага нь энэ параграфтаар шаардсан тоон шинжтэй тодруулгыг хүснэгтэн хэлбэрээр толилуулна.

34. Санхүүгийн хэрэглүүрийн зах зээл нь идэвхитэй биш бол байгууллага нь үнэлгээний арга зүйг ашигласнаар түүний бодит үнэ цэнийг тогтооно (УСНББОУС 29-ийн МЗУ106-МЗУ112-р параграфыг үзнэ үү). Гэвч УСНББОУС 29-ийн МЗУ108-р параграфт дурдсан нөхцөл биелэхээс бусад тохиолдолд анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь тухайн ажил гүйлгээний үнэ (өөрөөр хэлбэл, өгсөн эсвэл хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнэ) байдаг. Эндээс, анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ ба үнэлгээний арга зүйг ашигласнаар тэрхүү өдрөөр тодорхойлсон дүн хоорондоо зөрүүтэй байж болно гэж дүгнэж болно. Хэрэв ийм зөрүү байгаа бол байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн ангиар дараах зүйлсийг тодруулна:
- (а) Хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо тухайн зах зээлийн оролцогчдын харгалзан үзэх хүчин зүйлсийн (үүн дотроо, цаг хугацааны) өөрчлөлтийг тусгахын тулд уг зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх түүний нягтлан бодох бүртгэлийн бодлого (УСНББОУС 29-ийн МЗУ109-р параграфыг үзнэ үү); ба
- (б) Тухайн тайлант үеийн эхэн ба эцсийн байдлаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх нийт зөрүү, түүнчлэн энэхүү зөрүүний үлдэгдлийн өөрчлөлтийн тохируулга.
35. Дараах тохиолдолд бодит үнэ цэнийг тодруулах шаардлагагүй:
- (а) Дансны үнэ нь жишээлбэл, богино хугацаат худалдааны авлага ба өглөг гэх мэт санхүүгийн хэрэглүүрийн хувьд бодит үнэ цэнийн ул үндэслэлтэй ойролцоо дүн байх; эсвэл
- (б) Идэвхитэй зах зээл дэх зах зээлийн жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт эсвэл ийм өмчийн хэрэглүүртэй уялдсан бөгөөд бодит үнэ цэнийг нь найдвартай<sup>1</sup> хэмжиж чадахгүйн улмаас УСНББОУС 29-ийн дагуу өртгөөр хэмждэг үүсмэл хэрэглүүр; ба

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай

- (в) Сонголттой оролцох шинжийг нь найдвартай хэмжиж чадахгүй тийм Сонголттой оролцох шинж бүхий гэрээ.
36. 35(б) ба (в) параграфт дурдсан тохиолдлуудын хувьд, байгууллага нь тэдгээр санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох боломжит зөрүүгийн хэмжээний талаар өөрсдийн шүүн тунгааалтыг хийхэд тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах мэдээллийг, үүн дотроо дараах зүйлсийг тодруулна:
- (а) Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүйн улмаас тэдгээр хэрэглүүрүүдийн хувьд бодит үнэ цэнийн мэдээллийг тодруулаагүй тухай;
- (б) Санхүүгийн хэрэглүүрийн тайлбар тодорхойлолт, тэдгээрийн дансны үнэ, яагаад бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадаагүй талаархи тайлбар;
- (в) Тухайн хэрэглүүрийн зах зээлийн талаархи мэдээлэл;
- (г) Байгууллага нь уг санхүүгийн хэрэглүүрийг данснаас хасах санаа зорилготой байгаа эсэх, хэрхэн данснаас хасах талаархи мэдээлэл; ба
- (д) Бодит үнэ цэнийг өмнө нь найдвартай хэмжиж чадахгүй байсан санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрсөн бол энэ тухай, түүнчлэн уг үл хүлээн зөвшөөрөх үе дэх тэдгээрийн дансны үнэ, хүлээн зөвшөөрсөн олз буюу гарзын дүн.

*Хөнгөлөлттэй зээл*

37. Хөнгөлөлттэй зээл гэдэг нь зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцөлтэйгээр байгууллагын олгосон зээл юм. Байгууллагын олгодог хөнгөлөлттэй зээлийн жишээнд хөгжиж буй орнуудад олгосон зээл, жижиг аж ахуйд олгосон зээл, их дээд сургуулийн боловсролын шалгуур хангасан оюутнуудад олгосон оюутны зээл, бага орлоготой гэр бүлд олгосон өрхийн зээл хамаардаг. Олгосон хөнгөлөлттэй зээлийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Тухайн зээлийн эхний ба эцсийн дансны үнэ хоорондох тохируулга, үүнд:
- (i) Тухайн тайлант үеийн туршид олгосон шинэ зээлийн нэрлэсэн үнэ;
- (ii) Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнийн залруулга;
- (iii) Тайлант үеийн туршид буцаан төлсөн зээл;
- (iv) Хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз;

---

байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

- (v) Цаг хугацаа урсан өнгөрсөний үр дүнд уг дискаунтчилсан дүнд тухайн тайлант үеийн туршид гарсан аливаа нэмэгдэлт;
- (vi) Бусад өөрчлөлтүүд.
- (б) Тухайн тайлант үеийн эцэс дэх зээлийн нэрлэсэн үнэ цэнэ;
- (в) Төрөл бүрийн зээлийн зорилго ба хугацаа;
- (г) Үнэлгээний таамаглалууд.

### **Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдлийн шинж төрөл ба хэмжээ**

38. **Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх бөгөөд тухайн тайлант үеийн эцэст байгууллагад учрах эрсдлийн шинж төрөл ба хэмжээг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг уг байгууллага нь тодруулна.**
39. 40-49-р параграфтаар шаардсан тодруулга нь санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдэл болон тэдгээрийг хэрхэн удирдан зохицуулахад голлон чиглэнэ. Эдгээр эрсдэл нь ихэвчлэн зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, зах зээлийн эрсдлээс бүрдэх боловч үүгээр хязгаарлагдахгүй.

#### **Чанарын шинжтэй тодруулга**

40. Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдлийн төрөл тус бүрийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Эрсдэл өртөлт ба тэдгээр нь хэрхэн үүссэн эсэх;
  - (б) Эрсдлийг удирдан зохицуулах түүний зорилго, бодлого, үйл явц болон эрсдлийг хэмжихийн тулд ашигласан арга зүй;
  - (в) Дээрх (а) буюу (б)-д өмнөх тайлант үеэс хойш орсон өөрчлөлт.

#### **Тоон шинжтэй тодруулга**

41. Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдлийн төрөл тус бүрийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Тухайн тайлант үеийн эцэст уг эрсдэлд өртөх талаархи хураангуй тоон мэдээ. Энэхүү тодруулга нь тухайн байгууллагын удирдах зөвлөл буюу захирал гэх мэт эрх бүхий албан тушаалтанд (УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-д тодорхойлсон) дотооддоо танилцуулсан мэдээлэлд үндэслэдэг.
  - (б) Эрсдэл нь материаллаг бус байхаас бусад тохиолдолд 43-49-р параграфтаар шаардсан бөгөөд дээрх (а)-гийн дагуу бэлтгэж танилцуулснаас бусад тодруулга (материаллаг байдлын хэлэлцүүлгийг УСНББОУС 1-ийн 45-47-р параграфтаас үзнэ үү).
  - (в) Дээрх (а) ба (б)-д заасны дагуу хийсэн тодруулгаас хэрэв илт тодорхой биш бол эрсдлийн төвлөрөл.

42. Тухайн тайлант үеийн эцсийн байдлаар тодруулсан тоон шинжтэй мэдээ нь уг тайлант үеийн туршид байгууллагад учрах эрсдлийг төлөөлөн илэрхийлэхгүй байвал байгууллага нь төлөөлөн илэрхийлэх нэмэлт мэдээллээр хангана.

*Зээлийн эрсдэл*

43. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн ангиар дараах тодруулгыг хийнэ:
- (a) Эзэмшиж буй аливаа барьцаа буюу зээлийн бусад сайжруулалтыг харгалзаагүй тохиолдолд тухайн тайлант үеийн эцэст зээлийн эрсдэлд өртөх хамгийн их эрсдлийг хамгийн сайнаар илэрхийлэх дүн (жишээлбэл; УСНББОУС 28-д заасан харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах шалгуурыг хангахгүй цэвэр дүнгээр тооцох хэлцэл);
  - (б) Дээрх (a)-д тодруулсан дүнгийн хувьд баталгаа болгон эзэмшиж буй барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын талаархи тайлбар тодорхойлолт;
  - (в) Хугацаа өнгөрөөгүй, үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарын талаархи мэдээлэл; ба
  - (г) Нөхцлийг дахин хэлэлцэн тохироогүй бол хугацаа өнгөрөх эсвэл үнэ цэнэ буурах байсан санхүүгийн хөрөнгүүдийн дансны үнэ.

**Хугацаа өнгөрсөн буюу үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө**

44. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн ангиар дараах тодруулгыг хийнэ:
- (a) Тухайн тайлант үеийн эцсээр хугацаа өнгөрсөн боловч үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн насжилтын шинжилгээ;
  - (б) Тухайн тайлант үеийн эцсийн байдлаар үнэ цэнэ нь буурна гэж тус бүрд нь тодорхойлсон санхүүгийн хөрөнгүүдийн шинжилгээ, үүн дотроо тэдгээрийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохдоо уг байгууллагын харгалзан үзсэн хүчин зүйлс; ба
  - (в) Дээрх (a) ба (б)-д тодруулсан дүнгүүдийн хувьд, уг байгууллагын баталгаа болгон эзэмшиж буй барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын талаархи тайлбар тодорхойлолт, түүнчлэн практик боломжгүй биш бол тэдгээрийн бодит үнэ цэнийн тооцоолол.

**Олж эзэмшсэн барьцаа болон зээлийн бусад сайжруулалт**

45. Байгууллага нь баталгаа болгон эзэмшиж буй барьцаа буюу зээлийн бусад сайжруулалтыг (жишээлбэл; зээлийн баталгаа) харгалзан үзсэнээр тухайн тайлант үеийн туршид санхүүгийн буюу санхүүгийн бус хөрөнгийг хүлээн авсан бөгөөд ийм хөрөнгүүд нь бусад Стандартууд дахь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байвал уг байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (a) Хүлээн авсан хөрөнгүүдийн шинж төрөл ба дансны үнэ;

- (б) Тухайн хөрөнгийг мөнгөнд шууд хөрвүүлэх боломжгүй тохиолдолд ийм хөрөнгийг данснаас хасах эсвэл өөрийн үйл ажиллагаанд ашиглах талаархи түүний бодлого.

*Төлбөрийн чадварын эрсдэл*

46. Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийн (үүн дотроо, гаргасан санхүүгийн баталгааны гэрээний) хувьд гэрээний дуусгавар болох үлдсэн хугацааг харуулсан дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээ;
- (б) Үүсмэл санхүүгийн өр төлбөрийн дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээ. Мөнгөн гүйлгээний хугацааг ойлгоход гэрээний дуусгавар болох хугацаа нь чухал ач холбогдолтой байдаг тийм үүсмэл санхүүгийн өр төлбөрүүдийн гэрээний дуусгавар болох үлдсэн хугацааг уг дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээнд тусгана (МЗУ14-р параграфыг үзнэ үү).
- (в) Дээрх (а), (б)-д дурдсан төлбөрийн чадварын эрсдлийг хэрхэн удирдан зохицуулдаг талаархи тайлбар тодорхойлолт.

*Зах зээлийн эрсдэл*

**Мэдрэмжийн шинжилгээ**

47. Байгууллага нь 48-р параграфыг даган мөрддөг байхаас бусад тохиолдолд дараах зүйлсийг тодруулна:

- (а) Тухайн тайлант үеийн эцэст байгууллагад учрах зах зээлийн эрсдлийн төрөл тус бүрээр хийсэн мэдрэмжийн шинжилгээ, үүнд: уг өдөр ул үндэслэлтэйгээр боломжтой байсан холбогдох эрсдлийн хувьсагчийн өөрчлөлтүүд нь ашиг, алдагдал болон өмчид хэрхэн нөлөөлөхийг харуулна;
- (б) Мэдрэмжийн шинжилгээг бэлтгэхэд ашигласан арга болон таамаглал; ба
- (в) Ашиглах арга болон таамаглалд өмнөх тайлант үеэс хойш орсон өөрчлөлтүүд ба ийм өөрчлөлтийн учир шалтгаан.

48. Хэрэв байгууллага нь эрсдлийн хувьсагчдын (жишээлбэл; хүүний хувь хэмжээ, валютын ханш) хоорондох харилцан хамаарлыг тусгадаг “эрсдлийн үнэ цэнэ”<sup>2</sup> гэх мэт мэдрэмжийн шинжилгээг хийдэг бөгөөд санхүүгийн эрсдлийг удирдахдаа түүнийгээ хэрэглэдэг бол тухайн байгууллага нь 47-р параграфт дурдсан шинжилгээний оронд уг

---

<sup>2</sup> Value At Risk (VaR гэж товчилдог)-Эрсдлийн үнэ цэнэ гэдэг нь тодорхой хугацаан дахь санхүүгийн эрсдлийг тооцдог статистик арга зүй юм. Жишээлбэл; хувьцааны хөрөнгө оруулалт нь one-day 5% VaR of \$100 гэвэл хөрөнгө оруулалтын үнэ цэнэ 1 өдрийн дотор 100 ам доллараар буурах магадлал нь 5 хувь гэж ойлгоно. Ред.Ч.Д.

мэдрэмжийн шинжилгээг ашиглаж болно. Байгууллага нь мөн дараах зүйлсийг тодруулна:

- (а) Ийм мэдрэмжийн шинжилгээг хийхэд ашигласан арга, түүнчлэн өгөгдсөн тоон мэдээний үндэслэл болох гол үзүүлэлтүүд ба таамаглалуудын талаархи тайлбар; ба
- (б) Ашигласан аргын зорилго, түүнчлэн уг мэдээлэл нь тухайн хамаарах хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг бүрэн тусгахгүй байхад хүргэж болох хязгаарлалтуудын талаархи тайлбар.

#### **Зах зээлийн эрсдлийн бусад тодруулга**

- 49. 47 эсвэл 48-р параграфын дагуу тодруулсан мэдрэмжийн шинжилгээ нь санхүүгийн хэрэглүүрийн угийн эрсдлийг төлөөлөн илэрхийлэхгүй байх тохиолдолд (жишээлбэл; жилийн эцэс дэх эрсдэл нь тухайн жилийн турш дахь эрсдлийг тусган илэрхийлдэггүй учраас) байгууллага нь энэ тухай, түүнчлэн уг мэдрэмжийн шинжилгээ яагаад төлөөлөн илэрхийлэхгүй гэж үзэх болсон талаархи шалтгааныг тодруулна.

#### **Хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилт**

- 50. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**
- 51. **Хэрэв байгууллага нь УСНББОУС 28 ба УСНББОУС 30-ыг бас мөрддөг байхаас бусад тохиолдолд энэ Стандартыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө мөрдөхгүй.**
- 52. Хэрэв байгууллага нь 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант жилд энэ Стандартыг мөрдсөн бол тухайн байгууллага нь санхүүгийн хэрэглүүрүүдээс үүсэх эрсдлийн шинж төрөл ба хэмжээний талаар 38-49-р параграфтаар шаардсан тодруулгын хувьд зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах шаардлагагүй юм.
- 52A. **2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 53-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.**

- 52Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*, УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-ын үр дүнд 3(а), МЗУ6-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 35, УСНББОУС 37, УСНББОУС 38-ыг мөрдсөн үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөнө.
- 52В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар МЗУ7-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 52Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 6, 7-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 52Д. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 3-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.
53. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## **УСНББОУС 15 (2001 он)-аас татгалзах ба орлуулах**

54. Энэ Стандарт ба УСНББОУС 28 нь 2001 онд гаргасан УСНББОУС 15, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга ба Толилуулга*-ыг орлоно. УСНББОУС 28 ба УСНББОУС 30-ыг мөрдөх эсвэл тэдгээрийн хүчин төгөлдөр болох хугацааны аль түрүүнд болох өдөр хүртэл УСНББОУС 15-ыг мөрдсөн хэвээр байна.



## Хавсралт А

### Мөрдөх заавар удирдамж

*Энэ Хавсралт нь УСНББОУС 30-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

#### **Санхүүгийн хэрэглүүрийн ангиуд ба тодруулгын түвшин (9-р параграф)**

МЗУ1. 9-р параграф нь тодруулсан мэдээллийн шинж төрөлд тохирох бөгөөд тэдгээр санхүүгийн хэрэглүүрүүдийн шинж чанарыг харгалзсан ангиудаар санхүүгийн хэрэглүүрийг бүлэглэхийг байгууллагаас шаарддаг. 9-р параграфт дурдсан ангиудыг тухайн байгууллага тодорхойлдог, иймээс УСНББОУС 29-д тусгайлан заасан санхүүгийн хэрэглүүрийн ангиллаас (санхүүгийн хэрэглүүрийг хэрхэн хэмжих ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэрхэн хүлээн зөвшөөрөхийг тодорхойлсон) өөр байдаг.

МЗУ2. Санхүүгийн хэрэглүүрийн ангиудыг тодорхойлохдоо, байгууллага хамгийн наад зах нь:

- (а) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжсэн хэрэглүүрээс ялган зааглана.
- (б) Энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй санхүүгийн хэрэглүүрүүдийг тусдаа анги буюу ангиуд гэж үзнэ.

МЗУ3. Байгууллага нь энэ Стандартын шаардлагуудыг хангахын тулд хэр нарийвчилсан мэдээллээр хангах, уг шаардлагуудын янз бүрийн төлөв байдалд хэр их ач холбогдол өгөх эсэх, өөр өөр шинж чанар бүхий мэдээллийг нийлүүлэхгүйгээр ерөнхий дүр зургийг харуулахын тулд мэдээллийг хэрхэн нэгтгэх эсэхийг өөрийн нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач тусгүй байж болох хэт дэлгэрэнгүй мэдээллээр санхүүгийн тайланг дүүргэх ба хэт хураангуйлан нэгтгэснээр чухал мэдээллийг бүрхэгдүүлэхийн хоорондох зохистой тэнцвэрийг олох шаардлагатай байдаг. Жишээлбэл; байгууллага нь хангалттай дэлгэрэнгүй харуулаагүй том дүн дотор оруулснаар чухал мэдээллийг бүрхэгдүүлж болохгүй. Үүнтэй адилаар, байгууллага нь тухайн ажил гүйлгээ буюу холбогдох эрсдлийн хоорондох чухал ялгаатай байдлыг бүрхэгдүүлэх байдлаар уг нэгтгэсэн мэдээллийг салган тодруулж болохгүй юм.

#### **Санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрийн үзүүлэх ач холбогдол**

*Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр (13 ба 14-р параграф)*

МЗУ4. Хэрэв байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бол санхүүгийн өр

төлбөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамааруулж болох уг санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг тодруулахыг 13(а) параграфтаар шаарддаг. Зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэдэг зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд хамааруулж болохгүй уг өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүн байдлаар байгууллага нь энэхүү дүнг тодорхойлохыг 13(а)(i) параграфтаар зөвшөөрдөг. Хэрэв өр төлбөрийн хувьд зах зээлийн нөхцөл байдлын цорын ганц хамааралтай өөрчлөлт нь ажиглаж болох (бенчмарк) хүүний түвшний өөрчлөлт бол энэхүү дүнг дараах байдлаар тооцоолно:

- (а) Эхлээд, байгууллага нь тухайн тайлант үеийн эхэн дэх өр төлбөрийн ажигласан зах зээлийн үнэ ба өр төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээг ашиглан тэрхүү тайлант үеийн эхний байдлаар өр төлбөрийн өгөөжийн дотоод хувийг тооцоолно. Тус байгууллага нь өгөөжийн дотоод хувийн уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсгийг гаргахын тулд энэхүү өгөөжийн дотоод хувиас тухайн тайлант үеийн эхэн дэх тэрхүү ажигласан (бенчмарк) хүүний түвшинг хасна.
- (б) Үүний дараа, байгууллага нь тухайн тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээ болон (i) тухайн тайлант үеийн эцэст ажигласан (бенчмарк) хүүний түвшин, ба (ii) дээрх (а)-д тодорхойлсон, өгөөжийн дотоод хувийн уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсгийн нийлбэртэй тэнцүү байх дискаунтын хувийг ашигласнаар өр төлбөртэй холбоотой мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцоолно.
- (в) Тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн ажигласан зах зээлийн үнэ ба дээрх (б)-д тодорхойлсон дүн хоорондох зөрүү нь уг ажигласан (бенчмарк) хүүний түвшний өөрчлөлтөнд хамааруулж болохгүй бодит үнэ цэнийн өөрчлөлт юм. Энэ нь тодруулах дүн байна.

Тухайн хэрэглүүрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөөс бусад хүчин зүйлсээс үүссэн бодит үнэ цэнийн өөрчлөлт буюу хүүний түвшний өөрчлөлт нь энэ жишээний хувьд мэдэгдэхүйц биш гэж үзсэн. Энэ жишээн дэх хэрэглүүр нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг агуулдаг бол уг дагалдах үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг 13(а) параграфын дагуу тодруулах дүнг тодорхойлохдоо харгалзан оруулахгүй.

*Бусад тодруулга - Нягтлан бодох бүртгэлийн бодлого (25-р параграф)*

МЗУ5. 25-р параграф нь санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан хэмжилтийн суурь (буюу сууриуд) болон тухайн санхүүгийн тайланг ойлгоход ач холбогдолтой, ашигласан нягтлан бодох бүртгэлийн бусад бодлогуудыг тодруулахыг шаарддаг. Санхүүгийн хэрэглүүрийн хувьд ийм тодруулгад дараах зүйлс хамаарч болох юм:

- (а) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хувьд:

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

- (i) Байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн шинж төрөл;
  - (ii) Ийм санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед ингэж ангилах шалгуур; ба
  - (iii) Байгууллага нь ийм ангиллын хувьд УСНББОУС 29-ийн 10, 13, 14-р параграфын нөхцлүүдийг хэрхэн хангасан эсэх. УСНББОУС 29-д заасан, Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтын (б)(i) параграфын дагуу ангилсан хэрэглүүрүүдийн хувьд, ийм тодруулга нь үүсэх байсан хэмжилтийн буюу хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлын суурь үндэслэл болох нөхцөл байдлын талаархи хүүрнэсэн тайлбар тодорхойлолтыг агуулсан байдаг. УСНББОУС 29-д заасан, Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтын (б)(ii) параграфын дагуу ангилсан хэрэглүүрүүдийн хувьд, ийм тодруулга нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангилал тухайн байгууллагын баримтжуулсан эрсдлийн удирдлага буюу хөрөнгө оруулалтын стратегитай хэрхэн нийцэж байгаа талаархи хүүрнэсэн тайлбар тодорхойлолтыг агуулсан байдаг.
- (б) Санхүүгийн хөрөнгийг борлуулах боломжтой гэж ангилах шалгуур.
  - (в) Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцлөөр худалдан авалт ба борлуулалтыг арилжааны өдрөөр эсвэл барагдуулалтын өдрөөр тайлагнадаг эсэх (УСНББОУС 29-ийн 40-р параграфыг үзнэ үү).
  - (г) Зээлийн гарзын улмаас үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахын тулд хасагдуулгын данс ашигладаг тохиолдолд:
    - (i) Үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн дансны үнийг хэзээ шууд бууруулах (данснаас хассан авлагыг буцаах үед шууд нэмэгдүүлэх) эсвэл хэзээ хасагдуулгын данс ашиглах эсэхийг тодорхойлох шалгуур; ба
    - (ii) Хасагдуулгын дансанд тусгасан дүнгүүдийг уг үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн дансны үнээс хасах шалгуур (20-р параграфыг үзнэ үү).
  - (д) Санхүүгийн хэрэглүүрийн ангилал тус бүрийн хувьд цэвэр олз буюу цэвэр гарзыг хэрхэн тодорхойлдог (24(а) параграфыг үзнэ үү), жишээлбэл; ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг зүйлсийн цэвэр олз буюу цэвэр гарз нь хүүний орлого эсвэл ногдол ашиг болон адилтгах хуваарилалтаас үүссэн орлогыг агуулдаг эсэх.

- (е) Үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэсэн бодит нотолгоо байгаа эсэхийг тодорхойлохын тулд уг байгууллагын ашигладаг шалгуур (24(д) параграфыг үзнэ үү).
- (ж) Хугацаа өнгөрсөн эсвэл үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн нөхцлүүдийг дахин хэлэлцэн тохирсон тохиолдолд тэрхүү дахин хэлэлцсэн нөхцөлд хамаарсан санхүүгийн хөрөнгөнд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлого (43(г) параграфыг үзнэ үү).
- (и) Бодит үнэ цэнийг нь тодорхойлж чадахгүй арилжааны бус ажил гүйлгээгээр гаргасан бөгөөд хасагдуулгыг нь УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу байгуулсан санхүүгийн баталгааны гэрээний хувьд ингэж хасагдуулгыг хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн нөхцөл байдлын талаархи тодруулга.

Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдэд хамгийн их мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх уг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхдөө удирдлагын хийсэн шүүн тунгаалтыг тухайн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын тоймд эсвэл бусад тодруулгад, тооцоололтой холбоотой шүүн тунгаалтаас тусад нь тодруулахыг УСНББОУС 1-ийн 137-р параграфтаар бас шаардсан байдаг.

### **Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдлийн шинж төрөл ба хэмжээ (38-49-р параграф)**

МЗУ6. 38-49-р параграфтаар шаардсан тодруулгыг санхүүгийн тайланд эсвэл санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тэрхүү санхүүгийн тайлантай адил нөхцлөөр, ижил хугацаанд хүргэн танилцуулах боломжтой удирдлагын тайлбар буюу эрсдлийн тайлан гэх мэт өөр бусад тайланд тухайн санхүүгийн тайлангаас харилцан лавлагаа үүсгэснээр тусгана. Харилцан лавлагаа үүсгэснээр уг мэдээллийг тусгаагүй бол тухайн санхүүгийн тайлан нь иж бүрэн бус болно. Ийм харилцан лавлагааг ашиглах нь хууль тогтоомжийн хязгаарлалтанд захирагддаг байж болох юм.

#### *Тоон шинжтэй тодруулга (41-р параграф)*

МЗУ7. 41(а) параграф нь байгууллагын эрх бүхий албан тушаалтанд дотооддоо танилцуулдаг мэдээлэлд үндэслэсэн, уг байгууллагын эрсдэл өртөлтийн талаархи хураангуй тоон мэдээний тодруулга хийхийг шаарддаг. Байгууллага нь эрсдлийг удирдан зохицуулахын тулд хэд хэдэн аргыг ашигладаг бол тухайн байгууллага нь хамгийн их хамааралтай ба хамгийн найдвартай мэдээллээр хангах тийм арга буюу аргуудыг ашигласнаар мэдээллийг тодруулна. Хамааралтай ба найдвартай байдлыг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-нд авч хэлэлцсэн.

МЗУ8. 41(в) параграф нь эрсдлийн төвлөрлийн талаар тодруулга хийхийг шаарддаг. Эрсдлийн төвлөрөл нь ижил төсөөтэй шинж чанартай ба эдийн засгийн буюу бусад нөхцөл байдлын өөрчлөлтөөр ижил нөлөө

үзүүлдэг санхүүгийн хэрэглүүрүүдээс үүсдэг. Эрсдлийн төвлөрлийг тодорхойлохын тулд тухайн байгууллагын нөхцөл байдлыг харгалзан шүүн тунгаалт хийхийг шаарддаг. Эрсдлийн төвлөрлийн тодруулгад дараах зүйлс хамаарна:

- (а) Удирдлага нь төвлөрлийг хэрхэн тодорхойлдог талаархи тайлбар тодорхойлолт;
- (б) Төвлөрөл нэг бүрийг тодорхойлох уг нийтлэг шинж чанаруудын талаархи тайлбар тодорхойлолт (жишээлбэл; оролцогч нөгөө тал, газарзүйн бүс, валют буюу зах зээл); ба
- (в) Уг шинж чанар нийтлэг байх бүх санхүүгийн хэрэглүүртэй холбоотой эрсдлийн дүн.

*Зээлийн эрсдэлд өртөх хамгийн их дүн (43(а) параграф)*

МЗУ9. 43(а) параграф нь тухайн байгууллагын зээлийн эрсдэлд өртөх хамгийн их дүнг хамгийн сайн төлөөлөн илэрхийлэх дүнгийн тодруулга хийхийг шаарддаг. Санхүүгийн хөрөнгийн хувьд энэ нь ихэвчлэн дараах зүйлсийг хассан нийт дансны үнэ байдаг:

- (а) УСНББОУС 28-ын дагуу дагуу харилцан суутгаж, цэвэр дүнг гаргасан аливаа дүн; ба
- (б) УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн аливаа үнэ цэнийн бууралтын гарз.

МЗУ10. Зээлийн эрсдэл болон зээлийн эрсдлийн холбогдох хамгийн их өртөлтийг үүсэхэд хүргэх үйл ажиллагаанд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Үйлчлүүлэгчдэд зээл олгох ба бусад байгууллагуудад харилцах, хадгаламж байршуулах. Энэ тохиолдолд зээлийн эрсдэлд өртөлтийн хамгийн их дүн нь уг холбогдох санхүүгийн хөрөнгийн дансны үнэ байна.
- (б) Үүсмэл хэрэглүүрийн (жишээлбэл; гадаад валютын арилжааны гэрээ, хүүний түвшний своп, зээлийн үүсмэл хэрэглүүрийн) гэрээ байгуулах. Уг үр дүн болох хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг тохиолдолд тухайн тайлант үеийн эцэс дэх зээлийн эрсдэлд өртөлтийн хамгийн их дүн нь түүний дансны үнэтэй тэнцүү байна.
- (в) Санхүүгийн баталгаа гаргах. Энэ тохиолдолд зээлийн эрсдлийн хамгийн их өртөлт нь тухайн баталгааг шаардан нэхэмжилснээр уг байгууллага төлөх шаардлагатай болж болох хамгийн их дүн бөгөөд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн дүнгээс мэдэгдэхүйц их байж болох юм.

- (г) Уг хэрэглүүрийн хугацаанд буцаах боломжгүй эсвэл зөвхөн материаллаг сөрөг өөрчлөлтийн хариуд буцаах боломжтой зээл олгох баталгааг гаргах. Хэрэв гаргагч нь тухайн зээл олгох баталгааг цэвэр дүнгээр нь мөнгөөр эсвэл бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулж чадахгүй бол зээлийн эрсдлийн хамгийн их өртөлт тухайн зээл олгох баталгааны нийт дүн байна. Яагаад гэвэл, аливаа ашиглаагүй зээл олгох баталгааг ирээдүйд ашиглах эсэхээс хамааран энэ нь тодорхой бус байдаг. Энэ нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн дүнгээс мэдэгдэхүйц их байж болох юм.

*Төлбөрийн чадварын эрсдлийн тоон тодруулга (41(а), 46(а), (б) параграфыг үзнэ үү)*

МЗУ11. 41(а) параграфын дагуу байгууллага нь эрх бүхий албан тушаалтанд дотооддоо танилцуулдаг мэдээлэлд үндэслэн өөрийн төлбөрийн чадварын эрсдэлд өртөлтийн талаархи хураангуй тоон мэдээг тодруулна. Байгууллага нь эдгээр мэдээг хэрхэн тодорхойлдогийг тайлбарлана. Хэрэв эдгээр мэдээнд тусган оруулсан мөнгөн (буюу бусад санхүүгийн хөрөнгийн) зарлага нь:

- (а) уг мэдээнд заасан өдрөөс нилээд өмнө гарч тохиолддог, эсвэл
- (б) уг мэдээнд заасан дүнгээс мэдэгдэхүйц өөр (жишээлбэл; цэвэр дүнгээр барагдуулах сууриар тухайн мэдээнд тусган оруулсан боловч оролцогч нөгөө тал нь нийт дүнгээр барагдуулахаар шаардах сонголт бүхий үүсмэл хэрэглүүрийн хувьд),

бол байгууллага нь энэ тухай тодруулах бөгөөд 46(а) буюу (б) параграфтаар шаардсан гэрээний дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээнд тухайн мэдээллийг тусган оруулснаас бусад тохиолдолд энэхүү эрсдлийн хэмжээг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох тоон мэдээллээр хангана.

МЗУ12. 46(а) ба (б) параграфтаар шаардсан, дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээг бэлтгэх үедээ, байгууллага нь хугацааны мужийн тохиромжтой тоог тодорхойлохын тулд шүүн тунгаалт хийдэг. Жишээлбэл; байгууллага нь дараах хугацааны мужийг тохиромжтой гэж тодорхойлж болох юм:

- (а) нэг сараас хэтрэхгүй;
- (б) нэг сараас илүү боловч гурван сараас хэтрэхгүй;
- (в) гурван сараас илүү боловч нэг жилээс хэтрэхгүй; ба
- (г) нэг жилээс илүү боловч таван жилээс хэтрэхгүй.

МЗУ13. 46(а) ба (б) параграфыг даган мөрдөхдөө, байгууллага нь холимог (нийлмэл) санхүүгийн хэрэглүүрээс түүний дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлахгүй. Ийм хэрэглүүрийн хувьд байгууллага нь 46(а) параграфыг мөрдөнө.

МЗУ14. Хэрэв мөнгөн гүйлгээний хугацааг ойлгоход гэрээний дуусгавар болох хугацаа нь чухал ач холбогдолтой байдаг бол байгууллага нь үүсмэл санхүүгийн өр төлбөрийн хувьд гэрээний үлдсэн дуусгавар болох хугацааг харуулсан, дуусгавар болох хугацааны тоон задаргаа шинжилгээг тодруулахыг 46(б) параграфтаар шаардсан байдаг. Жишээлбэл; доорх зүйлсийн хувьд ийм тодруулга хийх шаардлагатай байна:

(а) Хувьсах хүүтэй санхүүгийн хөрөнгө буюу өр төлбөрийн мөнгөн гүйлгээний хейжийн хувьд 5 жилийн үлдсэн дуусгавар болох хугацаа бүхий хүүний түвшний своп.

(б) Зээл олгох бүх баталгаа.

МЗУ15. 46(а) ба (б) параграф нь санхүүгийн өр төлбөрийн дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээг тодруулахыг байгууллагаас шаарддаг бөгөөд үүнд зарим санхүүгийн өр төлбөрийн хувьд гэрээний үлдсэн дуусгавар болох хугацааг харуулдаг. Энэ тодруулгад:

(а) Хэрэв оролцогч нөгөө тал нь дүнг төлүүлэх хугацааг сонгодог бол тухайн байгууллагаас төлөхийг шаардаж болох хамгийн эхний тайлант үед уг өр төлбөрийг хуваарилан харуулна. Жишээлбэл; шаардсан даруйд буцаан төлөхийг байгууллагаас шаардаж болох санхүүгийн өр төлбөрийг (жишээлбэл; харилцах ба хугацаагүй хадгаламжийг) хугацааны хамгийн эхний мужид оруулан тусгана.

(б) Байгууллага нь дүнгүүдийг хэсэгчлэн төлөх үүрэг хүлээсэн тохиолдолд хэсэгчилсэн төлбөр нэг бүрийг уг байгууллагаас төлөхийг шаардаж болох хамгийн эхний тайлант үед хуваарилна. Жишээлбэл; зээл олгох ашиглаагүй баталгааг түүнийг ашиглаж болох хамгийн эхний өдрийг багтаасан хугацааны мужид оруулна тусгана.

(в) Гаргасан санхүүгийн баталгааны гэрээний хувьд, тухайн баталгааны хамгийн их дүнг уг баталгааг шаардаж болох хамгийн эхний тайлант үед хуваарилан тусгана.

МЗУ16. 46(а) ба (б) параграфтаар шаардсанчлан, дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээнд тодруулсан гэрээний дүн нь тухайн гэрээний дискаунтчлаагүй мөнгөн гүйлгээ байна. Жишээлбэл;

(а) Санхүүгийн түрээсийн нийт өр төлбөр (санхүүгийн зардлыг хасахын өмнөх);

(б) Санхүүгийн хөрөнгийг мөнгөөр худалдан авах форвард гэрээнд тусгайлан заасан үнэ;

(в) Цэвэр мөнгөн гүйлгээгээр арилжаалдаг, хөвөгч хүү төлөх/тогтмол хүү хүлээн авах свопын цэвэр дүн;

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

(г) Нийт мөнгөн гүйлгээгээр арилжаалдаг, үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг (жишээлбэл; валютын свопыг) арилжих гэрээний дүн; ба

(д) Зээл олгох баталгааны нийт дүн.

Санхүүгийн байдлын тайланд тусгасан дүн нь дискаунтчилсан мөнгөн гүйлгээнд үндэслэдэг учраас ийм дискаунтчлаагүй мөнгөн гүйлгээ нь уг тайланд тусгасан дүнгээс өөр байдаг. Хэрэв төлөх дүн нь тогтмол биш бол тухайн тайлант үеийн эцэст оршин буй нөхцөл байдлыг лавлагаа болгосноор уг тодруулах дүнг тодорхойлдог. Жишээлбэл; төлөх дүн нь индексийн өөрчлөлтөөс хамааран хувьсан өөрчлөгддөг тохиолдолд уг тодруулах дүн нь тухайн тайлант үеийн эцэс дэх индексийн түвшинд үндэслэж болох юм.

МЗУ17. 40(а) ба (б) параграфтаар шаардсан, тоон шинжтэй тодруулгад тусгасан зүйлсэд угаасаа байдаг төлбөрийн чадварын эрсдлээ байгууллага нь хэрхэн удирдан зохицуулдаг талаархи тодруулга хийхийг 46(в) параграфтаар шаардсан байдаг. Хэрэв төлбөрийн чадварын эрсдлийн шинж төрөл ба хэмжээг үнэлэх боломжийг тухайн санхүүгийн тайлангийг хэрэглэгчдэд олгоход уг мэдээлэл зайлшгүй шаардлагатай бол байгууллага нь төлбөрийн чадварын эрсдлээ удирдан зохицуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгүүдийн (жишээлбэл; шууд борлуулах боломжтой эсвэл санхүүгийн өр төлбөрийн мөнгөн зарлагыг барагдуулахуйц мөнгөн орлогыг үүсгэхээр хүлээгдэж буй санхүүгийн хөрөнгийн) дуусгавар болох хугацааны задаргаа шинжилгээг тодруулна.

МЗУ18. 40(в) параграфтаар шаардсан тодруулгыг бэлтгэхдээ байгууллагын харгалзан үзэж болох бусад хүчин зүйлсэд доорх зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй, үүнд байгууллага нь:

- (а) төлбөрийн чадварын хэрэгцээгээ хангахын тулд ашиглаж болох зээлийн хэрэглүүр (жишээлбэл; арилжааны бичиг) эсвэл зээлийн бусад шугамыг (жишээлбэл; хязгаар тогтоосон зээл) олгох баталгаа гаргадаг эсэх;
- (б) төлбөрийн чадварын хэрэгцээгээ хангахын тулд төв банкинд харилцах, хугацаагүй хадгаламж байршуулан эзэмшдэг эсэх;
- (в) санхүүжилтийн янз бүрийн эх үүсвэртэй эсэх;
- (г) хөрөнгө эсвэл санхүүжилтийн эх үүсвэрийн аль нэгний хувьд төлбөрийн чадварын эрсдлийн мэдэгдэхүйц төвлөрөлтэй эсэх;
- (д) төлбөрийн чадварын эрсдлээ удирдан зохицуулдаг дотоод хяналтын процесс ба болзошгүй байдлын төлөвлөгөөтэй эсэх.
- (е) хурдавчилсан байдлаар буцаан төлөх нөхцөл бүхий хэрэглүүртэй эсэх (жишээлбэл; байгууллагын зээлийн зэрэглэл буурсан үед);
- (ж) барьцаа байршуулахыг шаарддаг хэрэглүүртэй эсэх (жишээлбэл; барьцаа байршуулахыг шаарддаг үүсмэл хэрэглүүр);



- (и) мөнгө (буюу бусад санхүүгийн хөрөнгө) төлснөөр эсвэл өөрийн өмчийн хувьцааг өгснөөр санхүүгийн өр төлбөрөө барагдуулах эсэх сонголтыг байгууллагад олгодог хэрэглүүртэй эсэх;
- (к) цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэлд хамаарах хэрэглүүртэй эсэх.

*Зах зээлийн эрсдэл – мэдрэмжийн шинжилгээ (47, 48-р параграф)*

МЗУ19. 47(а) параграф нь байгууллагад учрах зах зээлийн эрсдлийн төрөл тус бүрээр мэдрэмжийн шинжилгээ хийхийг шаарддаг. МЗУ3-р параграфт заасанчлан, байгууллага нь өөр өөр шинж чанар бүхий мэдээллийг нийлүүлэхгүйгээр ерөнхий дүр зургийг харуулахын тулд эдийн засгийн эрс өөр орчноос үүссэн эрсдэлд өртөлтийн талаархи мэдээллийг хэрхэн нэгтгэхээ шийдвэрлэдэг. Тухайлбал;

- (а) Санхүүгийн хэрэглүүрийг худалдан борлуулдаг байгууллага нь худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж байгаа санхүүгийн хэрэглүүрийн талаархи энэхүү мэдээллийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшдэггүй хэрэглүүрийн талаархи мэдээллээс тусад нь тодруулж болох юм.
- (б) Байгууллага нь хэт инфляцитай бүс нутгаас үүсэх зах зээлийн эрсдлийг маш бага инфляцитай бүс нутгаас үүсэх зах зээлийн эрсдэлтэй нэгтгэн нийлүүлэхгүй.

Хэрэв байууллага нь эдийн засгийн зөвхөн нэг орчинд зөвхөн нэг төрлийн зах зээлийн эрсдэлд өртдөг бол мэдээллийг задлан харуулах шаардлагагүй юм.

МЗУ20. Холбогдох эрсдлийн хувьсагчийн (жишээлбэл; зах зээлийн давамгайлах хүүний түвшин, гадаад валютын ханш, өмчийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ) ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлтийн улмаас ашиг, алдагдал болон цэвэр хөрөнгө/өмчид үзүүлэх үр нөлөөг харуулахын тулд мэдрэмжийн шинжилгээ хийхийг 47(а) параграфтаар шаардсан байдаг. Энэ зорилгын хувьд:

- (а) Хэрэв холбогдох эрсдлийн хувьсагчид нь өөр байсан бол тухайн тайлант үеийн ашиг, алдагдал ямар байх байсныг байгууллага нь тодорхойлох шаардлагагүй юм. Харин холбогдох эрсдлийн хувьсагчийн ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлт нь тайлант үеийн эцэст гарч тохиолдсон бөгөөд уг өдрөөр оршин буй эрсдэлд түүнийг хэрэглэсэн гэж төсөөлвөл тухайн тайлант үеийн эцэст ашиг, алдагдал болон цэвэр хөрөнгө/өмчид үзүүлэх үр нөлөөг байгууллага нь тодруулна. Жишээлбэл; байгууллага нь тайлант жилийн эцэст хувьсах хүүтэй өр төлбөртэй боловч хүүний хувь хэмжээг ул үндэслэлтэйгээр боломжит дүнгээр өөрчилсөн бол тухайн тайлант жилийн ашиг, алдагдалд (өөрөөр хэлбэл, хүүний зардалд) үзүүлэх байсан үр нөлөөг уг байгууллага нь тодруулна.
- (б) Холбогдох эрсдлийн хувьсагчийн ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлтийн муж доторх өөрчлөлт нэг бүрийн ашиг, алдагдалд

болон цэвэр хөрөнгө/өмчид үзүүлэх үр нөлөөг байгууллага нь тодруулах шаардлагагүй юм. Тэрхүү ул үндэслэлтэйгээр боломжит мужийн хязгаараас давсан өөрчлөлтийн үр нөлөөг тодруулах нь хангалттай байдаг.

МЗУ21. Холбогдох эрсдлийн хувьсагчийн ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлт нь хэд байхыг тодорхойлохдоо байгууллага нь дараах зүйлсийг харгалзан үзнэ:

(а) Түүний үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн орчин. Ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлт нь магадлал багатай буюу “хамгийн муу тохиолдол” эсвэл “дарамт шахалттай нөхцөл” гэсэн хувилбарыг илэрхийлэхгүй. Түүнчлэн, хэрэв эрсдлийн суурь хувьсагчийн өөрчлөлтийн түвшин нь тогтвортой бол байгууллага нь уг сонгосон эрсдлийн хувьсагчийн ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлтийг засварлан өөрчлөх шаардлагагүй байдаг. Жишээлбэл; хүүний түвшин 5 хувь бөгөөд хүүний түвшний  $\pm 50$  суурь онооны хувьсан өөрчлөлтийг ул үндэслэлтэйгээр боломжит гэж байгууллага нь тодорхойлсон гэж үзье. Хэрэв хүүний түвшин нь 4.5% эсвэл 5.5% хүртэл өөрчлөгдсөн бол байгууллага нь ашиг, алдагдалд болон цэвэр хөрөнгө/өмчид түүний үзүүлэх үр нөлөөг тодруулна. Харин дараагийн тайлант үед хүүний түвшин нь 5.5% болж өссөн. Хүүний түвшин  $\pm 50$  суурь оноогоор хувьсан өөрчлөгдөж болно (өөрөөр хэлбэл, хүүний түвшний өөрчлөлт нь тогтвортой) гэж тухайн байгууллага нь дүгнэсэн хэвээр байна. Гэвч хүүний түвшин нь 5% эсвэл 6% хүртэл өөрчлөгдсөн бол байгууллага нь ашиг, алдагдалд болон цэвэр хөрөнгө/өмчид түүний үзүүлэх үр нөлөөг тодруулна. Хүүний түвшин эрс тогтворгүй болсон гэсэн нотолгоо байхаас бусад тохиолдолд байгууллага нь хүүний түвшин  $\pm 50$  суурь оноогоор ул үндэслэлтэйгээр хувьсан өөрчлөгдөж болно гэсэн өөрийн үнэлгээг засварлах шаардлагагүй байдаг.

(б) Үнэлгээг хийж буй холбогдох хугацааны муж. Байгууллага нь эдгээр тодруулгыг дараагийн удаа толилуулах хүртэл, ихэвчлэн дараагийн тайлант жил болох хүртэл хугацаанд ул үндэслэлтэйгээр боломжит байна гэж үзсэн өөрчлөлтийн үр нөлөөг уг мэдрэмжийн шинжилгээнд харуулдаг.

МЗУ22. Эрсдлийн хувьсагчдын хоорондох харилцан хамаарлыг тусгадаг “эрсдлийн үнэ цэнэ” гэх мэт мэдрэмжийн шинжилгээг санхүүгийн эрсдлийг удирдахдаа хэрэглэдэг бол байгууллага нь ийм мэдрэмжийн шинжилгээ ашиглахыг 48-р параграфтаар зөвшөөрсөн байдаг. Ийм арга зүй нь зөвхөн гарзын боломжийг хэмждэг, харин олзын боломжийг хэмждэггүй боловч үүнийг хэрэглэдэг. Ийм шинжилгээг хийдэг байгууллага нь уг ашигласан “эрсдлийн үнэ цэнэ”-ийн төрөл (жишээлбэл; уг загвар нь Монте Карлогийн загварчлалд тулгуурладаг эсэх), тухайн загвар хэрхэн ажилладаг талаархи тайлбар, гол таамаглалуудыг (жишээлбэл; эзэмших хугацаа ба найдвартай байдлын түвшин) тодруулснаар 48(а) параграфыг даган мөрдөж болох юм. Мөн

байгууллага нь түүхэн ажиглалтын тайлант үе, уг тайлант үеийн доторх ажиглалтуудад өгсөн хувийн жин, сонголтот боломжуудыг тооцоололд хэрхэн авч үзсэн ба ямар хувьсан өөрчлөлт болон харилцан хамаарлыг (өөр нэг хувилбар нь Монте Карлогийн магадлалын тархалтын загварчлалыг) ашигласан талаархи тайлбарыг бас тодруулж болох юм.

- МЗУ23. Байгууллага нь өөрийн үйл ажиллагааны хувьд бүхэлд нь мэдрэмжийн шинжилгээ хийдэг боловч санхүүгийн хэрэглүүрийн янз бүрийн ангиудад өөр өөр төрлийн мэдрэмжийн шинжилгээ хийж болох юм.

#### **Хүүний түвшний эрсдэл**

- МЗУ24. Хүүний түвшний эрсдэл нь санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн хүүтэй санхүүгийн хэрэглүүр (жишээлбэл; зээл ба авлага, гаргасан өрийн хэрэглүүр) ба санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөөгүй зарим санхүүгийн хэрэглүүр (жишээлбэл; зээл олгох зарим баталгаа)-ээс үүсдэг.

#### **Валютын эрсдэл**

- МЗУ25. Гадаад валютын эрсдэл (буюу гадаад валютын ханшийн эрсдэл) нь гадаад валютаар илэрхийлэгдсэн (өөрөөр хэлбэл, бүртгэлийн валютаас өөр валютаар хэмжсэн) санхүүгийн хэрэглүүрээс үүсдэг. Энэ Стандартын зорилгын хувьд, валютын эрсдэл нь мөнгөн бус зүйлс болох санхүүгийн хэрэглүүр эсвэл бүртгэлийн валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүрээс үүсдэггүй гэж үзнэ.
- МЗУ26. Байгууллагад мэдэгдэхүйц эрсдэл үүсгэдэг валют тус бүрийн хувьд мэдрэмжийн шинжилгээний тодруулга хийнэ.

#### **Үнийн бусад эрсдэл**

- МЗУ27. Үнийн бусад эрсдэл нь тухайлбал, бараа бүтээгдэхүүний үнэ эсвэл өмчийн үнийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн хувьд үүсдэг. 47-р параграфыг даган мөрдөхийн тулд байгууллага нь тохиролцсон хувьцааны зах зээлийн индекс, бараа бүтээгдэхүүний үнэ буюу эрсдлийн бусад хувьсагчийн бууралтын үр нөлөөг тодруулж болох юм. Жишээлбэл; байгууллага нь үлдэх үнэ цэнийн талаар баталгаа гаргадаг бөгөөд уг баталгаа нь санхүүгийн хэрэглүүр бол тухайн байгууллага нь тэрхүү баталгаанд хамааралтай хөрөнгийн үнэ цэнийн өсөлт буюу бууралтыг тодруулна.
- МЗУ28. Өмчийн үнийн эрсдэл үүсэхэд хүргэдэг санхүүгийн хэрэглүүрийн хоёр жишээ нь (а) өөр байгууллага дахь өмчийн эзэмшилт, (б) өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг эргээд эзэмшдэг итгэлцлийн санд оруулсан хөрөнгө оруулалт юм. Бусад жишээнд форвард гэрээ, тодорхой тооны өмчийн хэрэглүүрийг худалдан авах эсвэл борлуулах опцион, өмчийн үнээр индексжүүлсэн своп хамаарна. Ийм санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд уг суурь өмчийн хэрэглүүрийн зах зээлийн үнийн өөрчлөлт нөлөөлдөг.

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

- МЗУ29. 47(а) параграфын дагуу, ашиг, алдагдал өөрчлөгдөх мэдрэмжит байдлыг (жишээлбэл; ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан хэрэглүүрээс болон борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтаас үүсдэг) цэвэр хөрөнгө/өмчийн мэдрэмжит байдлаас (жишээлбэл; борлуулах боломжтой гэж ангилсан хэрэглүүрээс үүсдэг) тусад нь тодруулна.
- МЗУ30. Байгууллага нь өмчийн хэрэглүүр гэж ангилдаг санхүүгийн хэрэглүүрийг дахин хэмжихгүй. Ийм хэрэглүүрийн өмчийн үнийн эрсдэл нь ашиг, алдагдалд ч, цэвэр хөрөнгө/өмчид ч нөлөөлөхгүй. Иймээс мэдрэмжийн шинжилгээ хийх шаардлагагүй юм.

## Хавсралт Б

### Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 30-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Оршил

- ДҮ1. УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ын дүгнэлтүүдэд хүрэхдээ УСНББОУС3-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. Энэхүү Стандарт нь НББОУС3-өөс гаргасан СТОУС 7, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-д үндэслэсэн тул УСНББОУС 30 нь СТОУС 7-гийн үндсэн шаардлагуудаас гажих зөвхөн тэдгээр талбаруудыг энэ Дүгнэлтийн Үндэслэлд тусган илэрхийлсэн.
- ДҮ2. Санхүүгийн хэрэглүүрийн талаархи энэхүү төсөл нь УСНББОУС-ыг СТОУС-тай нийцүүлэхийг эрмэлзсэн УСНББОУС3-ийн нийцүүлэлтийн хөтөлбөрийн нэг хэсэг болно.
- ДҮ3. Энэ Стандартыг боловсруулахдаа, УСНББОУС3 нь тодруулгуудыг нэмэх эсвэл хасахад хүргэх улсын секторын аливаа тусгай асуудлуудыг авч үзсэнээс бусад тохиолдолд, одоо байгаа УСНББОУС-уудтай нийцэх СТОУС 7-гийн одоогийн текстийг тэр хэвээр хадгалахыг зөвшөөрсөн.
- ДҮ4. 2007 оны 9 дүгээр сард НББОУС3 нь НББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-ын Нэмэлт өөрчлөлтийг гаргасан бөгөөд ингэснээр санхүүгийн тайлангийн толилуулгад “дэлгэрэнгүй орлого” гэсэн шинэ бүрэлдэхүүн хэсгийг оруулсан. УСНББОУС3 нь НББОУС 1-д санал болгосон бусад зарим нэмэлт өөрчлөлтийн хамтаар дэлгэрэнгүй орлогыг хараахан авч хэлэлцээгүй байгаа тул тэдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 30-д тусган оруулаагүй.

### Хөнгөлөлттэй зээл

- ДҮ5. Хөнгөлөлттэй зээл гэдэг нь зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцөлтэйгээр байгууллагын олгосон эсвэл хүлээн авсан зээл юм. Байгууллагын олгодог хөнгөлөлттэй зээлийн жишээнд хөгжиж буй орнуудад олгосон зээл, жижиг аж ахуйд олгосон зээл, их дээд сургуулийн боловсролын шалгуур хангасан оюутнуудад олгосон оюутны зээл, бага орлоготой гэр бүлд олгосон өрхийн зээл хамаардаг. Ийм зээл нь улсын секторын шинжтэй байх бөгөөд Засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын нийгмийн бодлогуудыг хэрэгжүүлэхийн тулд үүнийг ихэвчлэн олгодог. Угаасаа хөнгөлөлттэй зээлийн санаа зорилго нь зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцөлтэйгээр нөөцийг олгох эсвэл хүлээн авах явдал байдаг. Ийм учраас УСНББОУС3 нь хөнгөлөлттэй зээлийн хувьд улсын секторын байгууллагууд илүү дэлгэрэнгүй тодруулга хийх шаардлагатай гэж үзсэн бөгөөд ийм зээлд зориулсан тодруулгын нэмэлт шаардлагуудыг 37-р параграфт тусган оруулсан.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 30-д хийсэн хянан засварлалт**

ДҮ6. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР УДИРДАМЖ

### АГУУЛГА

Танилцуулга	Параграф ХЗУ1-ХЗУ4
Материаллаг байдал	ХЗУ3-ХЗУ4
Санхүүгийн хэрэглүүрийн ангиуд ба тодруулгын түвшин	ХЗУ5-ХЗУ6
Санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрийн үзүүлэх ач холбогдол	ХЗУ7-ХЗУ16
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр	ХЗУ7-ХЗУ11
Үл биелүүлэлт ба зөрчил	ХЗУ12
Нийт хүүний зардал	ХЗУ13
Бодит үнэ цэнэ	ХЗУ14-ХЗУ16
Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдлийн шинж төрөл ба хэмжээ	ХЗУ17-ХЗУ40
Чанарын шинжтэй тодруулга	ХЗУ17-ХЗУ19
Тоон шинжтэй тодруулга	ХЗУ20-ХЗУ40
Зээлийн эрсдэл	ХЗУ23-ХЗУ31
Эзэмшиж буй аливаа барьцаа буюу зээлийн бусад сайжруулалт	ХЗУ24
Зээлийн чанар	ХЗУ25-ХЗУ27
Хугацаа өнгөрсөн эсвэл үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө	ХЗУ28-ХЗУ31
Зах зээлийн эрсдэл	ХЗУ32-ХЗУ40
Зах зээлийн эрсдлийн бусад тодруулга	ХЗУ37-ХЗУ40



## Хэрэгжүүлэх заавар удирдамж

*Энэхүү заавар удирдамж нь УСНББОУС 30-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Танилцуулга

- ХЗУ1. Энэхүү заавар удирдамж нь УСНББОУС 30-д заасан зарим тодруулгын шаардлагуудыг мөрдөх боломжит арга замуудыг санал болгоно. Энэ заавар удирдамж нь нэмэлт шаардлагуудыг бий болгохгүй.
- ХЗУ2. Тохиромжтой байлгах үүднээс энэ Стандартын тодруулгын шаардлага нэг бүрийг тусад нь авч үзсэн. Практикт, тодруулгуудыг ихэвчлэн нэгдсэн багц байдлаар толилуулдаг бөгөөд бие даасан тодруулгууд нь нэгээс олон шаардлагыг хангаж болох юм. Жишээлбэл, эрсдлийн төвлөрлийн талаархи мэдээлэл нь зээлийн буюу бусад эрсдэлд өртөлтийн талаархи мэдээллийг мөн илэрхийлж болох юм.

### Материаллаг байдал

- ХЗУ3. Хэрэв мэдээлэл материаллаг биш бол УСНББОУС-ын тодруулгын тусгай шаардлагыг биелүүлэх албагүй юм гэж УСНББОУС 1-д тэмдэглэсэн байдаг. УСНББОУС 1 нь материаллаг байдлыг дараах байдлаар тодорхойлсон:

Тухайн зүйлийн орхигдуулалт буюу буруу илэрхийлэлт нь уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн шийдвэр, хяналт үнэлгээнд дангаараа эсвэл хамтдаа нөлөө үзүүлж чадахаар байвал түүнийг материаллаг гэж үзнэ. Материаллаг байдал нь тухайн нөхцөл байдлын хүрээнд шүүн тунгаах уг орхигдуулалт буюу буруу илэрхийлэлтийн шинж төрөл ба хэмжээнээс хамаардаг. Тухайн зүйлийн хэмжээ эсвэл шинж төрөл нь, эсвэл хоёулаа нэгдсэн байдлаараа тодорхойлогч хүчин зүйл байж болох юм.

- ХЗУ4. Мөн УСНББОУС 1-д уг тодорхойлолтыг дараах байдлаар тайлбарласан:

Орхигдуулалт эсвэл буруу илэрхийлэлт нь хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлж чадах, иймээс материаллаг байх эсэхийг үнэлэхдээ тухайн хэрэглэгчдийн шинж төрлийг харгалзан үзэх шаардлагатай. Хэрэглэгчид нь улсын сектор, эдийн засгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн талаар зохих мэдлэгтэй бөгөөд тэд мэдээллийг ул үндэслэлтэй хянамгай байдлаар судлан мэдэх хүсэл эрмэлзэлтэй байдаг гэж төсөөлдөг. Тиймээс, ийм төлөв шинж бүхий хэрэглэгчдийн шийдвэрийн үнэлгээ болон гаргалтанд хэрхэн нөлөө үзүүлэхээр ул үндэслэлтэйгээр хүлээгдэж болохыг уг үнэлэлтэнд харгалзан үзэх шаардлагатай.

**Санхүүгийн хэрэглүүрийн ангиуд ба тодруулгын түвшин (9-р параграф ба МЗУ1-МЗУ3-р параграф)**

- ХЗУ5. МЗУ3-р параграфт “байгууллага нь энэ Стандартын шаардлагуудыг хангахын тулд хэр нарийвчилсан мэдээллээр хангах, уг шаардлагуудын янз бүрийн төлөв байдалд хэр их ач холбогдол өгөх эсэх, өөр өөр шинж чанар бүхий мэдээллийг нийлүүлэхгүйгээр ерөнхий дүр зургийг харуулахын тулд мэдээллийг хэрхэн нэгтгэх эсэхийг өөрийн нөхцөл байдлыг харгалзан шийдвэрлэнэ” гэж заасан. Эдгээр шаардлагуудыг хангахын тулд байгууллага нь энэ заавар удирдамжид санал болгосон бүх мэдээллийг толилуулах шаардлагагүй байж болох юм.
- ХЗУ6. УСНББОУС 1-ийн 29(в) параграф нь “УСНББОУС-ын тухайн тодорхой шаардлагуудыг даган мөрдөх нь байгууллагын санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд тодорхой нэг ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үзүүлэх үр нөлөөг ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгоход хангалтгүй байх тохиолдолд бусад нэмэлт тодруулгыг хийх”-ийг байгууллагаас шаарддаг.

**Санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд санхүүгийн хэрэглүүрийн үзүүлэх ач холбогдол (10-36-р параграф ба МЗУ4, МЗУ5-р параграф)**

*Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр (13(a)(i) параграф ба МЗУ4-р параграф)*

- ХЗУ7. Байгууллага нь энэхүү Стандартын Хавсралт А-гийн МЗУ4-р параграфын дагуу гүйцэтгэж болох тооцооллыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.
- ХЗУ8. 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд байгууллага нь 150,000 ТН<sup>3</sup>-ийн нэрлэсэн үнэтэй, 10 жилийн хугацаатай, жилийн 8 хувийн купоны тогтмол хүүтэй гаргасан бөгөөд хүүний түвшин нь ижил төсөөтэй шинж чанар бүхий бондуудын зах зээлийн хүүний түвшинтэй нийцэж байна.
- ХЗУ9. Байгууллага нь Лондонгийн Банк Хоорондын Санал Болгосон Хүү (LIBOR-ЛАЙБОР)-г өөрийн ажиглаж болох (бенчмарк) хүүний түвшин болгон ашигласан. Бондын үүссэн өдрөөр ЛАЙБОР нь 5 хувь байсан. Эхний жилийн эцэст:
- (а) ЛАЙБОР нь 4.75 хувь болж буурсан.
  - (б) Бондын бодит үнэ цэнэ нь 153,811 ТН буюу 7.6 хувийн хүүтэй адилтгах дүнтэй байсан.<sup>4</sup>
- ХЗУ10. Хүүний түвшний бүх өөрчлөлт нь өгөөжийн муруйн харгалзах өөрчлөлтийн үр дүн байх жигд өгөөжийн муруйтай бөгөөд зах зээлийн

<sup>3</sup> Энэхүү заавар удирдамжид мөнгөн дүнг “тоолох нэгж (ТН)” гэж тэмдэглэсэн.

<sup>4</sup> Энэ нь ЛАЙБОР 5 хувиас 4 хувь болсон өөрчлөлтийг илэрхийлэх бөгөөд зах зээлийн нөхцөл байдалд бусад холбогдох өөрчлөлт гараагүй тохиолдолд үүний 0.15 хувийн өөрчлөлт нь тухайн хэрэглүүрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтийг тусгана гэж үзнэ.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

нөхцөл байдлын цорын ганц холбогдох өөрчлөлт нь ЛАЙБОР-ын өөрчлөлт байна гэж уг байгууллага дүгнэсэн.

ХЗУ11. Байгууллага нь зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд хамааруулж болохгүй бөгөөд зах зээлийн эрсдэл үүсэхэд хүргэх уг бондын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг дараах байдлаар тооцоолсон:

<p>[МЗУ4(а) параграф]</p> <p>Эхлээд, байгууллага нь тухайн тайлант үеийн эхэн дэх өр төлбөрийн ажигласан зах зээлийн үнэ ба өр төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээг ашиглан тэрхүү тайлант үеийн эхний байдлаар өр төлбөрийн өгөөжийн дотоод хувийг тооцоолно.</p> <p>Тус байгууллага нь өгөөжийн дотоод хувийн уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсгийг гаргахын тулд энэхүү өгөөжийн дотоод хувиас тухайн тайлант үеийн эхэн дэх тэрхүү ажигласан (бенчмарк) хүүний түвшинг хасна.</p>	<p>10 жилийн хугацаатай, 8 хувийн купоны хүүтэй бондын тухайн тайлант үеийн эхэн дэх өгөөжийн дотоод хувь нь 8 хувь байсан.</p> <p>Ажигласан (бенчмарк) хүүний түвшин (ЛАЙБОР) нь 5 хувь учраас өгөөжийн дотоод хувийн уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсэг нь 3 хувь байна.</p>
<p>[МЗУ4(б) параграф]</p> <p>Үүний дараа, байгууллага нь тухайн тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн гэрээний мөнгөн гүйлгээ болон (i) тухайн тайлант үеийн эцэст ажигласан (бенчмарк) хүүний түвшин, ба (ii) дээрх (а)-д тодорхойлсон, өгөөжийн дотоод хувийн уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсгийн нийлбэртэй тэнцүү байх дискаунтын хувийг ашигласнаар өр төлбөртэй холбоотой мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцоолно.</p>	<p>Тухайн тайлант үеийн эцэст уг хэрэглүүрийн гэрээний мөнгөн гүйлгээ нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүү: 2-10 дахь жил тус бүрийн хувьд жил бүр 12,000 TH<sup>(a)</sup> байна.</li> <li>• Үндсэн дүн: 10 жилийн дараа 150,000 TH байна.</li> </ul> <p>Иймээс бондын өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход ашиглах дискаунтын хувь нь 7.75 хувь байх бөгөөд энэ нь тайлант үеийн эцэс дэх 4.75 хувийн ЛАЙБОР хүүн дээр уг хэрэглүүрт хамаарах тусгай бүрэлдэхүүн хэсгийн 3 хувийг нэмсэн дүн юм.</p> <p>Үүний үр дүнд өнөөгийн үнэ цэнэ нь 152,367 TH<sup>(b)</sup> болно.</p>

<p>[МЗУ4(в) параграф]</p> <p>Тайлант үеийн эцэс дэх өр төлбөрийн ажигласан зах зээлийн үнэ ба дээрх МЗУ4(б) параграфын дагуу тодорхойлсон дүн хоорондох зөрүү нь уг ажигласан (бенчмарк) хүүний түвшний өөрчлөлтөнд хамааруулж болохгүй бодит үнэ цэнийн өөрчлөлт юм. Энэ нь тодруулах дүн байна.</p>	<p>Тайлант үеийн эцэст өр төлбөрийн зах зээлийн үнэ нь 153,811 ТН<sup>(а)</sup> байна.</p> <p>Иймээс байгууллага нь зах зээлийн эрсдэл үүсгэх тухайн зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд хамааруулж болохгүй уг бондын бодит үнэ цэнийн өөрчлөлт болох 1,444 ТН (153,811 ТН – 152,367 ТН)-ийг тодруулна.</p>
<p><sup>(а)</sup> 150,000 ТН x 8% = 12,000 ТН</p>	
<p><sup>(б)</sup> <math>\text{ӨҮЦ (PV)} = [12,000 \text{ ТН} \times (1 - (1 + 0.0775)^{-9}) / 0.0775] + 150,000 \text{ ТН} \times (1 + 0.0775)^{-9}</math></p>	
<p><sup>(в)</sup> Зах зээлийн үнэ = <math>[12,000 \text{ ТН} \times (1 - (1 + 0.076)^{-9}) / 0.076] + 150,000 \text{ ТН} \times (1 + 0.076)^{-9}</math></p>	

*Үл биелүүлэлт ба зөрчил (22 ба 23-р параграф)*

ХЗУ12. Зээлийн өглөгийн аливаа үл биелүүлэлт буюу зөрчил гарсан тохиолдолд тодруулга хийхийг 22 ба 23-р параграфтаар шаарддаг. Аливаа үл биелүүлэлт буюу зөрчил нь УСНББОУС-1-ийн дагуу өр төлбөрийг богино эсвэл урт хугацаат гэж ангилах ангилалд нөлөөлж болох юм.

*Нийт хүүний зардал (24(б) параграф)*

ХЗУ13. 24(б) параграфын дагуу тодруулсан нийт хүүний зардал нь санхүүгийн зардлын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үүнийг санхүүгийн үр дүнгийн тайланд тусад нь толилуулахыг УСНББОУС 1-ийн 102(б) параграфтаар шаардсан байдаг. Санхүүгийн зардал гэсэн мөрийн зүйл нь мөн санхүүгийн бус өр төлбөртэй холбоотой хүүний зардлын дүнгүүдийг агуулсан байж болно.

*Бодит үнэ цэнэ (31-34-р параграф)*

ХЗУ14. Санхүүгийн байдлын тайланд хэмжиж тусгасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд бодит үнэ цэнийн хэмжилтийг ангилах бодит үнэ цэнийн шатлалын түвшингийн талаар тодруулга хийхийг УСНББОУС 30-аар шаарддаг. Өөр хэлбэр загвар илүү тохиромжтой байхаас бусад тохиолдолд хүснэгтэн хэлбэр ашиглахыг шаарддаг. 33(а) параграфыг даган мөрдөхийн тулд байгууллага нь хөрөнгийн хувьд дараах зүйлсийг тодруулж болно. (Зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулга хийхийг бас шаарддаг боловч энэ жишээнд тусган оруулаагүй болно.)

<b>Бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө</b>				
<b>Агуулга</b>	<b>20X2.12.31</b>	<b>Дараах мэдээллийг ашиглан тухайн тайлант үеийн эцэст бодит үнэ цэнийг хэмжих</b>		
		<b>Түвшин 1</b>	<b>Түвшин 2</b>	<b>Түвшин 3</b>
		<b>Сая ТН</b>	<b>Сая ТН</b>	<b>Сая ТН</b>
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө				
Худалдаа арилжааны үнэт цаас	100	40	55	5
Худалдаа арилжааны үүсмэл хэрэглүүр	39	17	20	2
Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө				
Өмчийн хөрөнгө оруулалт	75	30	40	5
<b>Нийт дүн</b>	<b>214</b>	<b>87</b>	<b>115</b>	<b>12</b>

Жич: Өр төлбөрийг үүнтэй ижил хүснэгтээр толилуулж болно.

ХЗУ15. Аливаа мэдэгдэхүйц орц нь ажиглаж болох зах зээлийн мэдээнд (Түвшин 3) үндэслээгүй үнэлгээний арга зүйгээр тооцсон бодит үнэ цэнээр тухайн санхүүгийн тайланд хэмжсэн тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн хувьд эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдэл хүртэлх тохируулгын тайланг тодруулахыг УСНББОУС 30-аар шаардсан байдаг. Өөр хэлбэр загвар илүү тохиромжтой байхаас бусад тохиолдолд хүснэгтэн хэлбэр ашиглахыг шаарддаг. 33(б) параграфыг даган мөрдөхийн тулд байгууллага нь хөрөнгийн хувьд дараах зүйлсийг тодруулж болно. (Зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулга хийхийг бас шаарддаг боловч энэ жишээнд тусган оруулаагүй болно.)

<b>Түвшин 3-д үндэслэн бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө</b>				
<b>Тайлант үеийн эцэс дэх бодит үнэ цэнийн хэмжилт</b>				
	<b>Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө</b>		<b>Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө</b>	<b>Дүн</b>
	Худалдаа арилжааны үнэт цаас	Худалдаа арилжааны үүсмэл хэрэглүүр	Өмчийн хөрөнгө оруулалт	
	Сая ТН	Сая ТН	Сая ТН	Сая ТН
Эхний үлдэгдэл	6	5	4	15
Нийт олз, гарз				
Ашиг, алдагдалд	(2)	(2)	-	(4)
Цэвэр хөрөнгө/өмчид	-	-	(1)	(1)
Худалдан авалт	1	2	2	5
Гаргалт	-	-	-	-
Барагдуулалт	-	(1)	-	(1)
Түвшин 3-с гаргах шилжүүлэлт	-	(2)	-	(2)
Эцсийн үлдэгдэл	5	2	5	12
Тайлант үеийн эцэст эзэмшиж буй хөрөнгийн хувьд ашиг, алдагдалд тусгах тухайн тайлант үеийн нийт олз, гарз	(1)	(1)	-	(2)
(Жич: Өр төлбөрийг үүнтэй ижил хүснэгтээр толилуулж болно.)				
Тайлант үеийн ашиг, алдагдалд тусган оруулсан олз, гарзыг дараах байдлаар орлогод толилуулна:				
Тайлант үеийн ашиг, алдагдалд тусган оруулсан нийт олз, гарз				Орлого (4)
Тухайн тайлант үеийн эцэст эзэмшиж буй хөрөнгийн хувьд ашиг, алдагдалд тусган оруулсан тайлант үеийн нийт олз, гарз				(2)
Жич: Өр төлбөрийг үүнтэй ижил хүснэгтээр толилуулж болно.				

ХЗУ16. Идэвхитэй зах зээлд арилжаалдаггүй санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнийг УСНББОУС 29-ийн МЗУ108-р параграфын дагуу тодорхойлдог. Гэвч анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа байгууллага нь ажиглаж болох зах зээлээс олж авч чадахгүй тоон мэдээг нэгтгэн гаргадаг үнэлгээний арга зүйг ашиглах тохиолдолд анхны хүлээн зөвшөөрөлтийн ажил гүйлгээний үнэ ба үнэлгээний арга зүй ашиглан анх хүлээн зөвшөөрөх үед тодорхойлсон дүн хооронд зөрүү үүсэж болох юм. Ийм тохиолдолд зөрүүг УСНББОУС 29 болон тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу дараагийн тайлант үеүдэд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Ийм хүлээн зөвшөөрөлт нь үнийг тогтоохдоо тухайн зах зээлийн оролцогчдын харгалзан үзэх хүчин зүйлсийн (үүн дотроо, цаг хугацааны) өөрчлөлтийг тусгадаг (УСНББОУС 29-ийн МЗУ108-р параграфыг үзнэ үү). Эдгээр тохиолдолд тодруулга хийхийг 33-р параграфтаар шаардсан байдаг. 34-р параграфыг даган мөрдөхийн тулд байгууллага нь дараах зүйлсийг тодруулж болох юм:

<b>Танилцуулга</b>
<p>20X1 оны 01 дүгээр сарын 01-нд байгууллага нь идэвхитэй зах зээлд арилжаалдаггүй санхүүгийн хөрөнгийг 15 сая ТН-ээр худалдан авсан. Байгууллага нь ийм санхүүгийн хөрөнгийн зөвхөн нэг ангитай.</p> <p>15 сая ТН-ийн ажил гүйлгээний үнэ нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ юм.</p> <p>Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоохын тулд үнэлгээний арга зүйг ашиглана. Энэхүү үнэлгээний арга зүй нь ажиглаж болох зах зээлийн мэдээнээс бусад хувьсагчдыг агуулсан байдаг.</p> <p>Анх хүлээн зөвшөөрөх үед уг үнэлгээний арга зүйг ашигласан бол 14 сая ТН бүхий дүнг гаргах байсан бөгөөд энэ нь бодит үнэ цэнээс 1 сая ТН-ээр зөрүүтэй байна.</p> <p>Байгууллага нь 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд 5 сая ТН-ийн зөрүүтэй байсан.</p>
<p><b>Шаардлагуудын даган мөрдөлт</b></p> <p>Тухайн байгууллагын 20X2 оны тодруулгад дараах зүйлс хамаарна:</p> <p><i>Нягтлан бодох бүртгэлийн бодлого:</i></p> <p>Идэвхитэй зах зээлд арилжаалдаггүй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохын тулд байгууллага нь дараах үнэлгээний арга зүйг ашигладаг: [үнэлгээний арга зүйн тайлбар тодорхойлолтыг энэ жишээнд тусган оруулаагүй болно]. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ (УСНББОУС 29-д заасанчлан, энэ нь ихэвчлэн ажил гүйлгээний үнэ байдаг) ба үнэлгээний арга зүйг ашиглан анх</p>

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

хүлээн зөвшөөрөх үед тодорхойлсон дүн хооронд зөрүү үүсэж болох юм. Ийм аливаа зөрүүг [тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын тайлбар тодорхойлолт] тусгана.

*Санхүүгийн тайлангийн тодруулгад:*

Тодруулга Х-д авч хэлэлцсэнчлэн, байгууллага нь идэвхитэй зах зээлд арилждаггүй дараах санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийг хэмжихийн тулд [үнэлгээний арга зүйн нэр]-г ашигладаг. Гэвч УСНББОУС 29-д заасанчлан, хэрэглүүрийн үүсэх үеийн бодит үнэ цэнэ нь ерөнхийдөө ажил гүйлгээний үнэ байдаг. Хэрэв ажил гүйлгээний үнэ нь хэрэглүүрийг анх үүсэх үед үнэлгээний арга зүйг ашиглан тодорхойлсон дүнгээс өөр байвал тэрхүү зөрүүг [тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын тайлбар тодорхойлолт] тусгана.

Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх зөрүү нь дараах байдалтай байна:

	<b>X2.12.31</b>	<b>X1.12.31</b>
	Сая ТН	Сая ТН
Жилийн эхний үлдэгдэл	5.3	5.0
Шинэ ажил гүйлгээ	-	1.0
Тухайн жилийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүн	(0.7)	(0.8)
Бусад нэмэгдэлт	-	0.2
Бусад бууралт	(0.1)	(0.1)
Жилийн эцсийн үлдэгдэл	4.5	5.3

**Санхүүгийн хэрэглүүрээс үүсэх эрсдлийн шинж төрөл ба хэмжээ (38-49-р параграф ба МЗУ6-МЗУ30-р параграф)**

*Чанарын шинжтэй тодруулга (40-р параграф)*

ХЗУ17. 40-р параграфын шаардлагуудыг хангахын тулд байгууллагын тодруулж болох чанарын шинжтэй мэдээллийн төрөлд дараах зүйлсийн талаархи хүүрнэсэн тайлбар хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Байгууллагын эрсдэлд өртөлт ба эрсдэл хэрхэн үүссэн эсэх. Эрсдэлд өртөлтийн талаархи мэдээлэл нь нийт ба цэвэр эрсдлийн шилжүүлэлт болон эрсдлийг бууруулах бусад ажил гүйлгээг илэрхийлж болно.
- (б) Доорх зүйлсийг агуулсан байж болох тухай байгууллагын эрсдлийг хүлээн зөвшөөрөх, хэмжих, хянан үнэлэх, хянах бодлого ба процесс:
  - (i) Байгууллагын эрсдлийн удирдлагын үүрэг ажиллагааны бүтэц ба зохион байгуулалт, үүн дотроо хараат бус байдал ба хариуцлагатай байдлын талаархи хэлэлцүүлэг;



## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

- (ii) Байгууллагын эрсдлийн тайлагнал буюу хэмжилтийн системийн цар хүрээ ба шинж төрөл;
  - (iii) Эрсдэлд хейж хийх буюу бууруулах тухайн байгууллагын бодлого, үүн дотроо барьцаа авах түүний бодлого ба горим;
  - (iv) Ийм хейж буюу эрсдлийг бууруулах арга хэрэгслийн байнгын үр дүнтэй байдлыг хянан үнэлэх уг байгууллагын процесс.
- (в) Эрсдлийн хэт төвлөрлөөс зайлсхийхэд зориулсан тухайн байгууллагын бодлого ба горим.
- ХЗУ18. Санхүүгийн хэрэглүүрүүдээс үүсэх эрсдлийн шинж төрөл ба хэмжээний талаархи мэдээлэл нь тухайн байгууллагын ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн, хугацаа, тодорхойгүй байдалд нөлөөлөх тэдгээр санхүүгийн хэрэглүүрүүдийн хоорондох аливаа харилцан хамаарлыг онцлон тэмдэглэдэг бол илүү их ач холбогдолтой байдаг. Ийм харилцан хамаарлаар эрсдэлд өртөлтийг өөрчлөх хэмжээ нь энэхүү Стандартаар шаардсан тодруулгуудаас хэрэглэгчдэд илт ойлгомжтой байж болох боловч зарим тохиолдолд цаашдын нэмэлт тодруулга хийх нь ач холбогдолтой байж болох юм.
- ХЗУ19. 40(в) параграфын дагуу байгууллагууд нь чанарын шинжтэй мэдээлэлд өмнөх тайлант үеэс хойш орсон аливаа өөрчлөлтийг тодруулах ба уг өөрчлөлтийн шалтгааныг тайлбарлана. Ийм өөрчлөлтүүд нь эрсдэлд өртөлтийн өөрчлөлтөөс эсвэл тэдгээр эрсдэл өртөлтийг удирдан зохицуулах арга замын өөрчлөлтөөс үүсэж болох юм.

### *Тоон шинжтэй тодруулга (41-49-р параграф ба МЗУ7-МЗУ30-р параграф)*

- ХЗУ20. 41-р параграф нь эрсдлийн төвлөрлийн талаархи тоон мэдээний тодруулга хийхийг шаарддаг. Жишээлбэл; зээлийн эрсдлийн төвлөрөл нь дараах зүйлсээс үүсэж болох юм:
- (а) Салбарын сектор. Хэрэв байгууллагын оролцогч нөгөө талууд нь салбарын нэг буюу хэд хэдэн секторт (жигжлэнгийн буюу бөөний худалдаа гэх мэт) төвлөрдөг бол байгууллага нь тэдгээр оролцогч талуудын төвлөрөл нэг бүрээс үүсэх эрсдэл өртөлтийг тусад нь тодруулна.
  - (б) Зээлийн зэрэглэл буюу зээлийн чанарын бусад хэмжүүр. Хэрэв байгууллагын оролцогч нөгөө талууд нь нэг буюу хэд хэдэн зээлийн чанарт (барьцаат зээл эсвэл барьцаагүй зээл гэх мэт), эсвэл нэг буюу хэд хэдэн зээлийн зэрэглэлд (хөрөнгө оруулалтын үнэлэмж буюу арилжааны үнэлэмж гэх мэт) төвлөрдөг бол байгууллага нь тэдгээр оролцогч талуудын төвлөрөл нэг бүрээс үүсэх эрсдэл өртөлтийг тусад нь тодруулна.
  - (в) Газарзүйн байршлын тархалт. Хэрэв байгууллагын оролцогч нөгөө талууд нь нэг буюу хэд хэдэн газарзүйн зах зээлд (Ази эсвэл Европ

гэх мэт) төвлөрдөг бол байгууллага нь тэдгээр оролцогч талуудын төвлөрөл нэг бүрээс үүсэх эрсдэл өртөлтийг тусад нь тодруулна.

- (г) Маш цөөн тооны бие даасан оролцогч талууд буюу ойрын холбоотой оролцогч талуудын бүлгүүд.

Бусад эрсдлүүдийн, үүн дотроо төлбөрийн чадварын эрсдэл ба зах зээлийн эрсдлийн төвлөрлийг тодорхойлохдоо үүнтэй адил зарчмуудыг мөрдөнө. Жишээлбэл; төлбөрийн чадварын эрсдлийн төвлөрөл нь санхүүгийн өр төлбөрийг буцаан төлөх нөхцөл, зээлийн хэрэгслийн эх үүсвэр, хөрвөх хөрөнгийг борлуулах тодорхой нэг зах зээл дэх найдлагаас үүсдэг байж болно. Хэрэв байгууллага нь нэг гадаад валютаар мэдэгдэхүйц хэмжээний нээлттэй цэвэр төлөв байдалтай<sup>5</sup> эсвэл нэг чиглэлд хамтдаа өөрчлөгдөх хэд хэдэн гадаад валютаар нээлттэй нэгдсэн цэвэр төлөв байдалтай байвал гадаад валютын ханшийн эрсдлийн төвлөрөл үүсэж болох юм.

ХЗУ21. МЗУ8-р параграфт заасанчлан, эрсдлийн төвлөрлийн тодруулга нь төвлөрөл нэг бүрийг тодорхойлох тухайн нийтлэг шинж чанаруудын талаархи тайлбар тодорхойлолтыг тусгасан байна. Жишээлбэл; оролцогч талуудыг улс орнуудын бүлгээр, бие даасан улсуудаар эсвэл улс доторх бүсүүдээр ангилсан газар зүйн байршлын тархалт нь нийтлэг шинж чанарт хамаарч болох юм.

ХЗУ22. Тайлант үеийн эцэс дэх тоон шинжтэй мэдээлэл нь тухайн тайлант үеийн туршид уг байгууллагад учрах эрсдэл өртөлтийг төлөөлөн илэрхийлж чадахгүй тохиолдолд цаашдын тодруулга хийхийг 42-р параграфтаар шаардсан байдаг. Энэхүү шаардлагыг хангахын тулд байгууллага нь тухайн тайлант үеийн туршид түүнд учирсан эрсдлийн хамгийн их, хамгийн бага болон дундаж дүнг тодруулж болох юм. Жишээлбэл; байгууллага нь тодорхой нэг валютын хувьд ихэвчлэн их хэмжээний эрсдэлтэй байдаг боловч жилийн эцэст уг төлөв байдлыг хаасан бол тухайн байгууллага нь тайлант үеийн турш дахь янз бүрийн хугацааны эрсдэл өртөлтийг харуулсан графикаар тодруулга хийх буюу хамгийн их, хамгийн бага болон дундаж эрсдэл өртөлтийг тодруулж болно.

### **Зээлийн эрсдэл (43-45-р параграф ба МЗУ9, МЗУ10-р параграф)**

ХЗУ23. Байгууллага нь өөрийн зээлийн эрсдэл өртөлтийн талаархи мэдээллийг санхүүгийн хэрэглүүрийн ангилар тодруулахыг 43-р параграфтаар шаардсан байдаг. Нэг ангийн санхүүгийн хэрэглүүрүүд нь уг тодруулга хийж буй эрсдлийн (энэ тохиолдолд зээлийн эрсдлийн) хувьд эдийн засгийн нийтлэг шинж чанаруудтай байдаг. Жишээлбэл; байгууллага нь

---

<sup>5</sup> Net open position-Нээлттэй төлөв цэвэр байдал. Жишээлбэл; байгууллага нь өөр нэг байгууллагын 500 ширхэг хувьцааг эзэмшиж байвал тухайн хувьцааны хувьд нээлттэй төлөв байдалтай гэж үзнэ. Харин байгууллага нь 2.0 сая ам долларын авлагатай, 1.5 сая ам долларын өглөгтэй бол ам долларын хувьд нээлттэй төлөв байдалтай бөгөөд 0.5 сая ам долларын нээлттэй цэвэр төлөв байдалтай гэж хэлж болно. Тус байгууллага нь авлага авч, өглөгөө төлж дууссан бол уг ам долларын төлөв байдал хаагдсан гэж үздэг байна. Ред.Ч.Д.

орон сууцны барьцаат зээл, хэрэглээний барьцаагүй зээл, арилжааны зээлийг тус бүрдээ эдийн засгийн өөр өөр шинж чанартай гэж тодорхойлж болох юм.

*Эзэмшиж буй аливаа барьцаа буюу зээлийн бусад сайжруулалт (43(б) параграф)*

ХЗУ24. Байгууллага нь өөрийн эзэмшиж буй хөрөнгийн хувьд баталгаа болгон авсан барьцаа болон зээлийн бусад сайжруулалтыг тодорхойлон тайлбарлахыг 43(б) параграфтаар шаардсан байдаг. Байгууллага нь дараах зүйлсийг тодруулснаар энэхүү шаардлагыг ханган биелүүлж болно:

- (а) Олж эзэмшсэн барьцаа болон зээлийн бусад сайжруулалтыг үнэлэх, удирдан зохицуулах бодлого ба процесс;
- (б) Барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын гол төрлүүдийн тайлбар тодорхойлолт (зээлийн бусад сайжруулалтын жишээнд зээлийн баталгаа, зээлийн үүсмэл хэрэглүүр, УСНББОУС 28-д заасан харилцан суутгаж, цэвэр дүн гаргах шалгуурыг хангахгүй харилцан суутгах гэрээ хамаарна);
- (в) Барьцаа болон зээлийн бусад сайжруулалтанд хамаарах оролцогч нөгөө талуудын гол төрөл ба тэдгээрийн зээлийн төлөх чадвар; ба
- (г) Барьцаа буюу зээлийн бусад сайжруулалтын хүрээн дэх эрсдлийн төвлөрлийн талаархи мэдээлэл.

*Зээлийн чанар (43(в) параграф)*

ХЗУ25. Байгууллага нь зээлийн эрсдэлтэй бөгөөд хугацаа өнгөрөөгүй, үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарын талаархи мэдээллийг тодруулахыг 43(в) параграфтаар шаардсан байдаг. Үүний тулд байгууллага нь дараах мэдээллийг тодруулж болох юм:

- (а) Гаднын болон дотоодын зээлийн үнэлэмжийн системийг ашигласнаар хийх зээлийн эрсдлийн шинжилгээ;
- (б) Оролцогч нөгөө талын шинж төрөл;
- (в) Оролцогч нөгөө талын үл биелүүлэлтийн хувь хэмжээний талаархи түүхэн мэдээлэл; ба
- (г) Зээлийн чанарыг үнэлэхэд ашигласан аливаа бусад мэдээлэл.

ХЗУ26. Зээлийн чанарыг удирдан зохицуулах ба хянан үнэлэхдээ байгууллага нь гаднын үнэлэмж зэрэглэлийг харгалзан үздэг тохиолдолд дараах зүйлсийн талаархи мэдээллийг тодруулж болно:

- (а) Зээлийн гаднын зэрэглэл тус бүрд хамаарах зээлийн эрсдэл өртөлтийн дүн;
- (б) Түүний ашигласан зэрэглэл тогтоодог агентлагууд;

- (в) Байгууллагын зэрэглэл тогтоосон ба зэрэглэл тогтоогоогүй зээлийн эрсдлийн дүн;
- (г) Гаднын болон дотоодын зэрэглэлийн хоорондох уялдаа холбоо.
- ХЗУ27. Зээлийн чанарыг удирдан зохицуулах ба хянан үнэлэхдээ байгууллага нь зээлийн дотоод зэрэглэлийг харгалзан үздэг тохиолдолд дараах зүйлсийн талаархи мэдээллийг тодруулж болно:
- (а) Зээлийн дотоод зэрэглэлийн процесс;
- (б) Зээлийн дотоод зэрэглэл тус бүрд хамаарах зээлийн эрсдэл өртөлтийн дүн; ба
- (в) Гаднын болон дотоодын зэрэглэлийн хоорондох уялдаа холбоо.
- Хугацаа өнгөрсөн эсвэл үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө (44-р параграф)*
- ХЗУ28. Оролцогч нөгөө тал нь гэрээний дагуу төлөх ёстой хугацаа болсон төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн хугацаа өнгөрсөн гэдэг. Жишээ болгон байгууллага нь хүүг сар бүр төлөхийг шаарддаг зээлийн гэрээг байгуулсан гэж үзье. Хэрэв дараагийн сарын эхний өдөр хүүг төлөөгүй бол уг зээлийн хугацаа өнгөрнө. Хугацаа өнгөрөлт гэдэг нь нөгөө тал хэзээ ч төлөхгүй гэсэн үг биш бөгөөд дахин хэлэлцэн тохиролцох, гэрээг албадан хэрэгжүүлэх, хуулийн ажиллагаа явуулах гэх мэт янз бүрийн арга хэмжээг эхлүүлж болно.
- ХЗУ29. Хугацаа өнгөрсөн гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн нөхцөл, болзлыг дахин хэлэлцэн тохиролцсон тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгийн хугацаа өнгөрсөн хэвээр байгаа эсэхийг тодорхойлохдоо шинэ гэрээний тохиролцооны нөхцөл, болзлыг харгалзан үзнэ.
- ХЗУ30. Хугацаа өнгөрсөн боловч үнэ цэнэ буураагүй санхүүгийн хөрөнгийн насжилтын ангиар шинжилгээ хийхийг 44(а) параграфтаар шаардсан байдаг. Байгууллага нь хугацааны мужийн тохиромжтой тоог тодорхойлохын тулд өөрийн шүүн тунгаалтыг ашигладаг. Жишээлбэл; байгууллага нь дараах хугацааны мужийг тохиромжтой гэж тодорхойлж болох юм:
- (а) Гурван сараас хэтрэхгүй;
- (б) Гурван сараас илүү боловч зургаан сараас хэтрэхгүй;
- (в) Зургаан сараас илүү боловч нэг жилээс хэтрэхгүй;
- (г) Нэг жилээс дээш.
- ХЗУ31. Үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгүүдийн ангиар шинжилгээ хийхийг 44(б) параграфтаар шаардсан байдаг. Ийм шинжилгээнд дараах зүйлс хамаарч болно:
- (а) Аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хасахын өмнөх дансны дүн;

- (б) Аливаа холбогдох үнэ цэнийн бууралтын гарзын дүн; ба
- (в) Олж зээмшсэн барьцаа болон зээлийн бусад сайжруулалтын шинж төрөл ба бодит үнэ цэнэ.

**Зах зээлийн эрсдэл (47-49-р параграф ба МЗУ19-МЗУ30-р параграф)**

ХЗУ32. 47(а) параграф нь тухайн байгууллагад учрах зах зээлийн эрсдлийн төрөл тус бүрээр мэдрэмжийн шинжилгээ хийхийг шаарддаг. Хүүний түвшний эрсдэл, валютын эрсдэл, үнийн бусад эрсдэл гэсэн зах зээлийн эрсдлийн гурван төрөл байдаг. Үнийн бусад эрсдэлд өмчийн үнийн эрсдэл, бараа бүтээгдэхүүний үнийн эрсдэл, урьдчилан төлөлтийн эрсдэл (өөрөөр хэлбэл, нөгөө тал нь хүлээгдэж байснаас эрт эсвэл хожуу буцаан төлсний улмаас тухайн санхүүгийн хөрөнгийн оролцогч тал нь санхүүгийн гарз хүлээх эрсдэл), үлдэх үнэ цэнийн эрсдэл (жишээлбэл; үлдэх үнэ цэнийн баталгаа гаргасан, автомашины түрээслүүлэгч нь үлдэх үнэ цэнийн эрсдэлд өртдөг) хамаарч болох юм. Зах зээлийн эрсдлийн тодруулгатай холбоотой эрсдлийн хувьсагчдад дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Зах зээлийн хүүний түвшний өгөөжийн муруй. Өгөөжийн муруй дахь зэрэгцээ болон зэрэгцээ бус шилжилт өөрчлөлтийг харгалзан үзэх шаардлагатай байж болно.
- (б) Гадаад валютын ханш.
- (в) Өмчийн хэрэглүүрийн үнэ.
- (г) Бараа бүтээгдэхүүний зах зээлийн үнэ.

ХЗУ33. Холбогдох эрсдлийн хувьсагчийн ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлтийн ашиг, алдагдалд болон цэвэр хөрөнгө/өмчид үзүүлэх үр нөлөөг харуулах мэдрэмжийн шинжилгээ хийхийг 47(а) параграфтаар шаардсан байдаг. Жишээлбэл; холбогдох эрсдлийн хувьсагчдад дараах зүйлс хамаарч болно:

- (а) Хувьсах хүүтэй зээл гэх мэт хүүний мэдрэмжтэй санхүүгийн хэрэглүүрийн хувьд зах зээлийн давамгайлах хүүний түвшин; эсвэл
- (б) Гадаад валютаар гаргасан бонд гэх мэт гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэглүүрийн хувьд валютын ханш ба хүүний түвшин.

ХЗУ34. Хүүний түвшний эрсдлийн хувьд, мэдрэмжийн шинжилгээ нь дараах зүйлсэд зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөөг тусад нь харуулж болох юм:

- (а) Хүүний орлого ба хүүний зардал;
- (б) Ашиг, алдагдлын бусад мөрийн зүйлс (арилжааны олз ба гарз гэх мэт);
- (в) Хэрэв хамааралтай бол цэвэр хөрөнгө/өмч.

Байгууллага нь хүүний түвшний материаллаг эрсдэлтэй байж болох валют тус бүрийн хувьд хүүний түвшний эрсдэлд хамаарах мэдрэмжийн шинжилгээг тодруулж болно.

- ХЗУ35. Зах зээлийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлс нь байгууллага нэг бүрийн тусгай нөхцөл байдлаас хамаардаг учраас зах зээлийн эрсдлийн мэдрэмжийн шинжилгээг хийхэд харгалзан үзэх тохиромжтой муж нь байгууллага бүрд болон зах зээлийн эрсдлийн төрөл тус бүрийн хувьд өөр өөр байдаг.
- ХЗУ36. 47(а) параграфт заасан, тодруулгын шаардлагыг хэрхэн мөрдөхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан:

**Хүүний түвшний эрсдэл**

20X2 оны 12 дугаар сарын 31-нд хэрэв бусад бүх хувьсагч тогтмол байхад хүүний түвшин нь уг өдөр 10 суурь оноогоор бага байсан бол тухайн жилийн ашиг нь хувьсах хүүтэй зээлийн арай бага хүүний зардлаас үндсэндээ хамааран 1.7 сая ТН-ээр илүү (20X1 онд 2.4 сая ТН байсан), харин бусад орлого нь борлуулах боломжтой гэж ангилсан тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өсөлтөөс үндсэндээ хамааран 2.8 сая ТН-ээр илүү (20X1 онд 3.2 сая ТН байсан) байх байсан. Хэрэв бусад бүх хувьсагч тогтмол байхад хүүний түвшин нь 10 суурь оноогоор их байсан бол тухайн жилийн ашиг нь хувьсах хүүтэй зээлийн арай өндөр хүүний зардлаас үндсэндээ хамааран 1.5 сая ТН-ээр бага (20X1 онд 2.1 сая ТН байсан), харин бусад орлого нь борлуулах боломжтой гэж ангилсан тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өсөлтөөс үндсэндээ хамааран 3.0 сая ТН-ээр бага (20X1 онд 3.4 сая ТН байсан) байх байсан. Хязгаар тогтоосон хүүтэй зээлээс хамааран ашиг нь хүүний түвшний өсөлтөнд биш, харин хүүний түвшний бууралтанд илүү мэдрэмжтэй байна. Тухайн байгууллагын өрийн хугацаа дууссанаар төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл буурсаны үр дүнд мэдрэмж нь 20X1 онтой харьцуулахад 20X2 онд арай бага байна (Тодруулга Х-ыг үзнэ үү).<sup>(a)</sup>

**Гадаад валютын ханшийн эрсдэл**

20X2 оны 12 дугаар сарын 31-нд хэрэв бусад бүх хувьсагч тогтмол байхад ТН-ийн ам доллартай харьцах ханш нь 10 хувиар суларсан бол тухайн жилийн ашиг нь 2.8 сая ТН-ээр бага (20X1 онд 6.4 сая ТН байсан), орлого нь 1.2 сая ТН-ээр их (20X1 онд 1.1 сая ТН байсан) болох байсан. Харин эсрэгээр, хэрэв бусад бүх хувьсагч тогтмол байхад ТН-ийн ам доллартай харьцах ханш нь 10 хувиар чангарсан бол тухайн жилийн ашиг нь 2.8 сая ТН-ээр их (20X1 онд 6.4 сая ТН байсан), орлого нь 1.2 сая ТН-ээр бага (20X1 онд 1.1 сая ТН байсан) болох байсан. 20X1 онтой харьцуулахад 20X2 оны ашиг дахь гадаад валютын ханшийн мэдрэмж бага байгаа нь гадаад валютаар илэрхийлэгдсэн өр буурсантай холбоотой юм. Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр буурснаар нөхөгдөх гадаад валютаар хийсэн

худалдан авалтын хейжийн ашиглалт нэмэгдсэний улмаас орлого нь 20X1 онтой харьцуулахад 20X2 онд илүү мэдрэмжтэй байна.

(a) Өр төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг тодруулахыг 46(a) параграфтаар шаардсан байдаг.

*Зах зээлийн эрсдлийн бусад тодруулга (49-р параграф)*

ХЗУ37. Тодруулга байдлаар харуулсан мэдрэмжийн шинжилгээ нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн угийн эрсдлийг төлөөлөн илэрхийлэхгүй тохиолдолд нэмэлт мэдээллийн тодруулга хийхийг 49-р параграфтаар шаардсан байдаг. Жишээлбэл; дараах тохиолдолд ийм нөхцөл үүсэж болно:

- (a) Санхүүгийн хэрэглүүр нь түүний үр нөлөө мэдрэмжийн шинжилгээгээр илт тодорхой бус байх тийм нөхцөл, болзлуудыг агуулсан байх (жишээлбэл; эрсдлийн хувьсагчийн сонгосон өөрчлөлтийн хувьд мөнгөн алдагдалтай (эсвэл мөнгөн ашигтай) байх опцион);
- (б) Санхүүгийн хөрөнгө нь хөрвөх чадваргүй байх (жишээлбэл; ижил төсөөтэй хөрөнгүүдийн хувьд ажил гүйлгээ цөөн байх бөгөөд байгууллага нь оролцогч нөгөө талыг олоход хүндрэлтэй гэж үзсэн); эсвэл
- (в) Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн том хэмжээний эзэмшилтэй бөгөөд хэрэв бүгдийг нь борлуулвал жижиг эзэмшлийн зах зээлийн жишиг үнэтэй харьцуулахад хөнгөлөлттэй эсвэл урамшуулалттай үнээр борлуулахаар байх.

ХЗУ38. ХЗУ37(a) параграфт дурдсан нөхцөл байдлын хувьд нэмэлт тодруулга нь дараах зүйлсийг агуулсан байж болно:

- (a) Санхүүгийн хэрэглүүрийн нөхцөл ба болзол (жишээлбэл; опцион);
- (б) Хэрэв нөхцөл, болзол нь биелэгдвэл (өөрөөр хэлбэл, опционыг хэрэгжүүлвэл) ашиг, алдагдалд түүний үзүүлэх үр нөлөө; ба
- (в) Эрсдэлд хэрхэн хейж хийсэн талаархи тайлбар тодорхойлолт.

Тухайлбал; байгууллага нь мөнгөн алдагдалтай, хөшүүрэгдсэн, гаргасан опцион бүхий (жишээлбэл; байгууллага нь тогтоосон хүүний түвшний доод хэмжээ ба одоогийн зах зээлийн хүүний түвшний хоорондох зөрүү дүнг арав дахин нэмэгдүүлсэн дүнг төлөх) тэг өртөгтэй хүүний түвшний баталгааг олж эзэмшсэн байж болно. Уг хүүний түвшний баталгааг байгууллага нь хүүний түвшний ул үндэслэлтэйгээр боломжит өсөлтийн хувьд хийгдэх өндөр зардалгүй, хэмнэлттэй хейж гэж үзэж болох юм. Гэвч хүүний түвшний хүлээгдээгүй их хэмжээний бууралт нь хөшүүргийн үр нөлөөний улмаас уг гаргасан опционы дагуу төлөх төлбөрүүдийг тухайн хүүний арай бага түвшний хэмнэлтээс мэдэгдэхүйц их хэмжээтэй болоход хүргэж болох юм. Хүүний түвшний бодит үнэ цэнэ болон зах

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОДРУУЛГА

зээлийн хувьсагчдын ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлтөнд үндэслэсэн мэдрэмжийн шинжилгээний аль аль нь энэхүү эрсдэл өртөлтийг илэрхийлэхгүй. Энэ тохиолдолд байгууллага нь дээр дурдсан нэмэлт мэдээллээр хангаж болох юм.

ХЗУ39. ХЗУ38(б) параграфт дурдсан нөхцөл байдлын хувьд, ийм нэмэлт тодруулгад төлбөрийн чадваргүй байдлын учир шалтгаан, уг эрсдэлд байгууллага хэрхэн хейж хийснийг тусган харуулж болно.

ХЗУ40. ХЗУ38(в) параграфт дурдсан нөхцөл байдлын хувьд, нэмэлт тодруулга нь дараах зүйлсийг агуулсан байж болно:

- (а) Барьцаа баталгааны шинж төрөл (жишээлбэл; байгууллагын нэр);
- (б) Эзэмшлийн хэмжээ (жишээлбэл; гаргасан хувьцааны 15 хувь);
- (в) Ашиг, алдагдалд үзүүлэх үр нөлөө; ба
- (г) Байгууллага нь уг эрсдэлд хэрхэн хейж хийдэг эсэх.



## СТОУС 7-ТОЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ыг СТОУС 7, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-аас (2005 онд анх гаргасан бөгөөд 2009 оны 4 дүгээр сар хүртэл нэвлэн нийтэлсэн нэмэлт өөрчлөлтүүд багтсан) үндсэндээ бэлтгэсэн болно. УСНББОУС 30 ба СТОУС 7-гийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 30 нь хөнгөлөлттэй зээлтэй холбоотой шаардлагуудыг агуулсан байдаг. СТОУС 7 нь хөнгөлөлттэй зээлтэй холбоотойгоор тодруулга хийхийг шаарддаггүй.
- УСНББОУС 30 нь зарим тохиолдолд СТОУС 7-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 30 дахь “орлого” /revenue/, “санхүүгийн үр дүнгийн тайлан”, “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. СТОУС 7 дахь адилтгах нэр томъёо нь “орлого” /income/, “дэлгэрэнгүй орлогын тайлан”, “өмч” юм.

## УСНББОУС 31–БИЕТ БУС ХӨРӨНГӨ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 38, *Биет Бус Хөрөнгө*-өөс үндсэндээ бэлтгэсэн болно. Мөн энэ нь Тайлбарын Байнгын Хорооны Тайлбар 32 (ТБХ 32), *Биет Бус Хөрөнгө-Вэб Сайтын Өртөг*-өөс авсан ишлэлүүдийг тусгасан болно. НББОУС 32, ТБХ 32-оос авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 31-БИЕТ БУС ХӨРӨНГӨ

### УСНББОУС-ЫН ТҮҮХ

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө-ийг 2010 оны 01 дүгээр сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 31-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нээдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт (УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-ын нэмэлт өөрчлөлтүүд) (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2014-ийн Сайжруулалтууд (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)

### УСНББОУС 31-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
3	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

5	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар УСНББОУС 32, 2011 оны 10-р сар УСНББОУС 39, 2016 оны 7-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
18	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
18А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
24	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
26А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
28	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
35	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
39А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
39Б	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
39В	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
39Г	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
39Д	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
40	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
41	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
64	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
66	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
67	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
79	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
91	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
93А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
96	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
97	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
97А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
97Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
97В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

110	Нэмэлт өөрчлөлт	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
114А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
116	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
117	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
129	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
130	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
131	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
131А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
132А	Шинэ	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
132Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
132В	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
132Г	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
132Д	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
132Е	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
132Ж	Шинэ	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
132И	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
132К	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
133	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

**УСНББОУС 31–БИЕТ БУС ХӨРӨНГӨ**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-15
Биет бус соёлын өв хөрөнгө	11-15
Тодорхойлолт	16-25
Биет бус хөрөнгө	17-25
Тодорхойлж болох байдал	18-20
Хөрөнгийн хяналт	21-24
Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи	25
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	26-65
Тусад нь худалдаж авах	32-39
Нэгдлийн (улсын секторын нэгдлийн) нэг хэсэг байдлаар биет бус хөрөнгийг олж эзэмших	39А-39Д
Олж эзэмшсэн дуусаагүй судалгаа ба хөгжүүлэлтийн төслийн дараагийн тайлант үеийн зарлага	40-41
Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биет бус хөрөнгө	42-43
Хөрөнгийн солилцоо	44-45
Дотооддоо бий болгосон гүүдвил	46-48
Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө	49-65
Судалгааны үе шат	52-54
Хөгжүүлэлтийн үе шат	55-62
Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн өртөг	63-65
Зардлын хүлээн зөвшөөрөлт	66-70
Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй өнгөрсөн зардлууд	70
Дараагийн тайлант үеийн хэмжилт	71-86
Өртгийн загвар	73
Дахин үнэлгээний загвар	74-86
Ашиглалтын хугацаа	87-95
Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө	96-105
Хорогдуулгын хугацаа ба хорогдуулгын арга	96-98
Үлдэх өртөг	99-102
Хорогдуулгын хугацаа ба хорогдуулгын аргыг хянах	103-105
Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө	106-109
Ашиглалтын хугацааны үнэлгээг хянах	108-109
Дансны үнийн нөхөгдөх байдал - Үнэ цэнийн бууралтын гарз	110
Ашиглалтыг зогсоолт ба данснаас хасалт	111-116
Тодруулга	117-127
Ерөнхий зүйл	117-122

## БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Хүлээн зөвшөөрөлтийн дараа дахин үнэлгээний загвар ашиглан хэмжсэн биет бус хөрөнгө	123-124
Судалгаа ба хөгжүүлэлтийн зардал	125-126
Бусад мэдээлэл	127
Шилжилтийн нөхцөл	128-131
Хүчин төгөлдөр болох хугацаа	132-133
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Үлгэрчилсэн жишээ	
НББОУС 38-тай харьцуулалт	

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 31, *Биет Бус Хөрөнгө*-ийг 1-133-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 31-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.



## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь бусад Стандартад тусгайлан авч үзээгүй биет бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг тодорхойлоход оршино. Энэ Стандарт нь тусгайлан заасан шалгуур зөвхөн хангагдсан үед биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийг байгууллагаас шаарддаг. Мөн энэ Стандарт нь биет бус хөрөнгийн дансны үнийг хэрхэн хэмжихийг заасан бөгөөд биет бус хөрөнгийн талаар тусгайлан тодруулга хийхийг шаарддаг.

## Цар хүрээ

2. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь биет бус хөрөнгийн тайлагналд энэ Стандартыг мөрдөнө.
3. Энэ Стандартыг доор дурдснаас бусад, биет бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэлд мөрдөнө:
  - (a) Бусад Стандартын цар хүрээнд хамаардаг биет бус хөрөнгө;
  - (b) УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга-д* тодорхойлсон санхүүгийн хөрөнгө;
  - (b) Хайгуул ба үнэлгээний хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт (ашигт малтмалын хайгуул ба үнэлгээг бүртгэх олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг үзнэ үү);
  - (г) Ашигт малтмал, газрын тос, байгалийн хий болон тэдгээртэй адилтгах үл нөхөн сэргээгдэх нөөцийн хөгжүүлэлт ба олборлолтын зардал;
  - (д) [Хассан]
  - (e) [Хассан]
  - (ж) Хууль тогтоомж, дүрэм буюу адилтгах арга хэрэгслээр олгосон бүрэн эрх ба эрх;
  - (и) Хойшлогдсон татварын хөрөнгө (орлогын татварыг бүртгэх олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг үзнэ үү);
  - (к) Даатгалын гэрээг авч үздэг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын цар хүрээнд хамаарах даатгалын гэрээгээрх даатгагчийн гэрээний эрхээс үүсэх хойшлогдсон худалдан авалтын өртөг ба биет бус хөрөнгө. Олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт нь эдгээр биет бус хөрөнгийн хувьд тодруулгын тусгай шаардлагуудыг тогтоодоггүй тохиолдолд уг биет бус хөрөнгүүдэд энэ Стандартын тодруулгын шаардлагуудыг мөрдөнө; ба

- (л) [Хассан]
- (м) **Биет бус соёлын өв хөрөнгийн хувьд. Гэхдээ хүлээн зөвшөөрсөн тэдгээр соёлын өв хөрөнгүүдэд 115-127-р параграфын тодруулгын шаардлагуудыг мөрдөнө.**
4. [Хассан]
5. [Хассан]
6. Хэрэв бусад Стандарт нь тодорхой нэг төрлийн биет бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг тодорхойлсон бол байгууллага нь энэ Стандартыг биш, харин тухайн хамаарах Стандартыг мөрдөнө. Тухайлбал, энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөхгүй:
- (а) Хэвийн үйл ажиллагааны явцад байгууллага нь борлуулах зорилгоор эзэмшиж буй биет бус хөрөнгө (УСНББОУС 11, *Барилгын Гэрээ* ба УСНББОУС 12, *Бараа Материал*-ыг үзнэ үү);
  - (б) УСНББОУС 13, *Түрээс*-ийн цар хүрээнд хамаарах түрээс;
  - (в) Ажилтны тэтгэмжээс үүсэх хөрөнгө (УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг үзнэ үү).
  - (г) УСНББОУС 28-д тодорхойлсон санхүүгийн хөрөнгө. Зарим санхүүгийн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр Дэх Хөрөнгө Оруулалт*-д авч үзсэн байдаг;
  - (д) УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ийн цар хүрээнд хамаарах үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба анхны хэмжилт. Гэхдээ энэ Стандартыг ийм хөрөнгүүдийн дараагийн тайлант үеийн хэмжилт ба тодруулгад мөрдөнө; ба
  - (е) Гүүдвил (УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийг үзнэ үү).
7. Зарим биет бус хөрөнгө нь компакт диск (CD) (компьютерийн программ хангамжийн хувьд), эрх зүйн баримт бичиг (лиценз эсвэл патентын хувьд), дэлгэцэнд гаргах хальс гэх мэт биет шинж чанартайгаар хадгалагддаг байж болно. Биет бус ба биет элементүүдийн аль алиныг агуулсан хөрөнгийг УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийн дагуу биет хөрөнгө эсвэл энэ Стандартын дагуу биет бус хөрөнгө гэж үзэх эсэхийг тодорхойлохдоо, байгууллага нь аль элемент илүү чухал ач холбогдолтой байгааг үнэлэх үүднээс шүүн тунгаалт хийдэг. Жишээлбэл; байлдааны усан онгоцны жолоодлогын программ хангамж нь уг усан онгоцны салшгүй нэг хэсэг бөгөөд түүнийг үндсэн хөрөнгө гэж үзнэ. Энэ зарчмыг компьютерийн үйлдлийн системийн хувьд мөрдөнө. Программ хангамж нь холбогдох техник хэрэгслийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг биш байх тохиолдолд компьютерийн программ хангамжийг биет бус хөрөнгө гэж үзнэ.

8. Энэ Стандартыг бусад зүйлсээс гадна зар сурталчилгаа, сургалт, гарааны зардал, судалгаа ба хөгжүүлэлтийн зардалд мөрдөнө. Судалгаа ба хөгжүүлэлтийн үйл ажиллагаа нь мэдлэгийг хөгжүүлэхэд чиглэгдсэн байдаг. Иймээс эдгээр үйл ажиллагаа нь биет шинжтэй хөрөнгийг (жишээлбэл; эх загварыг) бий болгох үр дүнтэй байж болох боловч тухайн хөрөнгийн биет элемент нь түүний биет бус бүрэлдэхүүн хэсгийн, өөрөөр хэлбэл, түүнд агуулагдаж буй мэдлэгийн хувьд дагалдах шинжтэй байдаг.
9. Санхүүгийн түрээсийн хувьд, суурь хөрөнгө нь биет эсвэл биет бус хөрөнгө байж болно. Санхүүгийн түрээсийн дагуу эзэмшиж буй биет бус хөрөнгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа түрээслэгч нь энэ Стандартын дагуу тайлагнана. Кино хальс, дүрс бичлэг, урлагийн тоглолт, гар бичмэл, патент, зохиогчийн эрх гэх мэт зүйлсийг лицензийн гэрээгээр эзэмших эрх нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах бөгөөд УСНББОУС 13-ын цар хүрээнд хамаарахгүй.
10. Үйл ажиллагаа буюу ажил гүйлгээ нь өөр байдлаар авч үзэх шаардлагатай байж болох нягтлан бодох бүртгэлийн асуудлуудыг үүсгэхээр тийм тусгай шинжтэй бол энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй байж болох юм. Олборлох салбарын газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын хайгуул, хөгжүүлэлт, олборлолтын зардал болон даатгалын гэрээний нягтлан бодох бүртгэлийн хувьд ийм асуудлууд үүсдэг. Иймээс энэ Стандартыг тэдгээр үйл ажиллагааны зардал ба гэрээний хувьд мөрдөхгүй. Харин олборлох салбарт эсвэл даатгагчийн ашигласан бусад биет бус хөрөнгө (компьютерийн программ хангамж гэх мэт) болон гарсан бусад зардлын (гарааны зардал гэх мэт) хувьд энэ Стандартыг мөрдөнө.

#### **Биет бус соёлын өв хөрөнгө**

11. Энэ Стандарт нь биет бус хөрөнгийн тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй биет бус соёлын өв хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийг байгууллагаас шаардахгүй. Хэрэв байгууллага нь биет бус соёлын өв хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг бол энэ Стандартын тодруулгын шаардлагуудыг мөрдөх ёстой, харин энэ Стандартын хэмжилтийн шаардлагуудыг мөрдөх албагүй боловч мөрдөж болох юм.
12. Зарим хөрөнгийг тэдгээрийн соёлын, байгаль орчны эсвэл түүхийн ач холбогдлоос хамааран биет бус соёлын өв хөрөнгө гэж тодорхойлдог. Биет бус соёлын өв хөрөнгийн жишээнд түүхэн томоохон үйл явдлын дүрс бичлэг, олонд алдартай хүний хөрөг зургийг тухайлбал, шуудангийн марк, цуглуулгын зоосон мөнгөн дээр ашиглах эрх хамаарна. Биет бус соёлын өв хөрөнгө нь дараах гэх мэт ихэвчлэн тодорхой шинж чанаруудтай байдаг (гэхдээ эдгээр шинж чанарууд нь ийм хөрөнгөнд цор ганц байдаггүй):
  - (a) Тэдгээрийн соёлын, байгаль орчны болон түүхэн нөхцлөөр илэрхийлэгдэх үнэ цэнэ нь зах зээлийн үнэд зөвхөн үндэслэсэн санхүүгийн үнэ цэнээр бүрэн тусгагдах магадлал багатай байдаг;

- (б) Хууль ба/буюу зохицуулалтын үүрэг нь тэдгээрийг борлуулж данснаас хасахыг хориглох буюу хатуу хязгаарлалт тогтоож болох юм;
  - (в) Тэдгээрийн үнэ цэнэ нь цаг хугацааны явцад өсдөг байж болно;
  - (г) Тэдгээрийн ашиглалтын хугацааг тооцоолоход хүндрэлтэй бөгөөд зарим тохиолдолд хэдэн зуун жил байж болох юм.
13. Улсын секторын байгууллагууд нь худалдан авалт, хандив, гэрээслэл, улсын орлого болгон хураалт гэх мэт янз бүрийн арга замаар олон жилийн хугацаанд олж эзэмшсэн биет бус соёлын томоохон өв хөрөнгөтэй байж болох юм. Эдгээр хөрөнгийг мөнгөн орлого бий болгох тэдгээрийн чадвар боломжийн дагуу бараг эзэмшдэггүй бөгөөд ийм зорилгоор ашиглахад хуулийн буюу нийгмийн саад хязгаарлалттай байж болно.
14. Зарим биет бус соёлын өв хөрөнгө нь өөрийн өвийн үнэ цэнээс гадна ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхитай байдаг. Жишээлбэл; түүхэн дүрс бичлэгийг ашиглахын тулд тухайн байгууллагад төлсөн эрхийн шимтгэл. Энэ тохиолдолд биет бус соёлын өвийг мөнгө бий болгогч биет бус хөрөнгийн бусад зүйлстэй ижил сууриар хүлээн зөвшөөрч, хэмжиж болно. Биет бус соёлын бусад өв хөрөнгийн хувьд тэдгээрийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тэдгээр өвийн шинж чанараар хязгаарлагддаг. Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж ба үйлчилгээний чадавхийн аль алины оршин байдал нь хэмжилтийн суурийн сонголтонд нөлөөлдөг.
15. 117-124-р параграфт дурдсан, тодруулгын шаардлагууд нь тухайн хүлээн зөвшөөрсөн биет бус хөрөнгийн талаар тодруулга хийхийг байгууллагуудаас шаарддаг. Иймээс биет бус соёлын өв хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг байгууллагууд нь эдгээр хөрөнгүүдийн хувьд тухайлбал, дараах гэх мэт зүйлсийг тодруулах шаардлагатай байдаг:
- (а) Ашигласан хэмжилтийн суурь;
  - (б) Хэрэв байгаа бол ашигласан хорогдуулгын арга;
  - (в) Нийт дансны үнэ;
  - (г) Хэрэв байгаа бол тухайн тайлант үеийн эцэс дэх хуримтлагдсан хорогдуулга;
  - (д) Тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнийн тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан тохируулгын тайлан.

## Тодорхойлолт

16. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**
- Хорогдуулга** гэдэг нь биет бус хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт юм.

**Дансны үнэ** гэдэг нь аливаа хуримтлагдсан хорогдуулга ба хуримтлагдсан үнэ цэнэ бууралтын гарзыг хассаны дараа, хөрөнгийг хүлээн зөвшөөрч байгаа дүн юм.

**Хөгжүүлэлт** гэдэг нь шинэ буюу мэдэгдэхүйц сайжруулсан материал, төхөөрөмж, бүтээгдэхүүн, процесс, системийн үйлдвэрлэл эсвэл үйлчилгээний төлөвлөлт, зохиомжинд судалгааны үр дүн болон бусад мэдлэгийг, тэдгээрийн арилжааны зорилготой үйлдвэрлэл, ашиглалт эхлэхээс өмнө хэрэглэх үйл ажиллагаа юм.

**Биет бус хөрөнгө** гэдэг нь биет шинж чанаргүй, тодорхойлж болох мөнгөн бус зүйлсийн хөрөнгө юм.

**Судалгаа** гэдэг нь шинжлэх ухааны буюу техникийн шинэ мэдлэг, ойлголт олж авах хэтийн зорилготойгоор хийгдэж буй бодит, төлөвлөгдсөн судлан шинжлэх үйл явц юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

#### **Биет бус хөрөнгө**

17. Байгууллага нь шинжлэх ухааны буюу техникийн мэдлэг, шинэ процесс буюу системийн зохиомж ба хэрэгжүүлэлт, лиценз, оюуны өмч, зах зээлийн мэдлэг, худалдааны тэмдэг (үүнд: брэндийн нэр ба хэвлэлийн эрх) гэх мэт биет бус нөөцүүдийг худалдаж авах, хөгжүүлэх, хэвийн хадгалах буюу сайжруулахад байнга хөрөнгө мөнгө зарцуулж эсвэл үүрэг хариуцлага хүлээж байдаг. Эдгээр ерөнхий гарчгийн доор агуулагдах зүйлсийн нийтлэг жишээнд дараах зүйлс хамаарна. Үүнд: компьютерийн программ хангамж, патент, зохиогчийн эрх, киноны эрх, үйлчилгээ хэрэглэгчдийн жагсаалт, загасчлах зөвшөөрөл, импортын квот, үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцаа.

#### *Тодорхойлж болох байдал*

18. 17-р параграфт дурдсан бүх зүйлс нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг, өөрөөр хэлбэл тодорхойлж болох, нөөцийг хянах, ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхитай байх гэсэн шинжүүдийг хангана гэсэн үг биш юм. Хэрэв энэ Стандартын цар хүрээнд хамаарах зүйл нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй бол уг зүйлийг худалдан авах эсвэл дотооддоо бий болгоход гаргасан зарлагыг түүнийг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө. Харин тухайн зүйлийг нэгдлийн үед олж авсан бол энэ нь уг нэгдлийн өдрөөр хүлээн зөвшөөрөх гүүдвилийн нэг хэсгийг бүрдүүлнэ (66-р параграфыг үзнэ үү).
- 18А. Биет бус хөрөнгийн тодорхойлолт нь түүнийг гүүдвилээс ялгахын тулд тодорхойлж болохуйц байхыг уг биет бус хөрөнгөөс шаарддаг. Нэгдлээр хүлээн зөвшөөрсөн гүүдвил нь уг нэгдлээр олж авсан бусад хөрөнгүүдээс

бий болох ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлэх боловч бие даасан байдлаар тодорхойлж, тусдаа хүлээн зөвшөөрөх боломжгүй хөрөнгө юм. Энэхүү ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь олж авсан тэдгээр тодорхойлж болох хөрөнгүүдийн өргөжилтийн хэмнэлтээс эсвэл санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шалгуурыг бие даан хангахгүй хөрөнгүүдээс үүсэж болох юм.

19. **Хөрөнгө нь дараах шалгуурын аль нэгийг хангаж байвал түүнийг тодорхойлж болох хөрөнгө гэж үзнэ:**
- (a) **Салган тусгаарлах, өөрөөр хэлбэл тухайн байгууллагаас тусгаарлах буюу салган хувааж болох ба уг байгууллага тийм санаа зорилготой эсэхээс үл хамааран холбогдох гэрээ, тодорхойлж болох хөрөнгө буюу өр төлбөрөөс бие даасан байдлаар эсвэл хамтад нь борлуулах, шилжүүлэх, лицензээр эзэмшүүлэх, түрээслэх, солилцох боломжтой байх; эсвэл**
  - (б) **Гэрээний буюу бусад хуулийн эрхийг шилжүүлж болох буюу уг байгууллагаас эсвэл өөр бусад эрх, үүргээс салган тусгаарлаж болох эсэхээс үл хамааран заавал биелүүлэх хэлцлээс (тухайн гэрээний буюу бусад хуулийн эрхээс) үүсдэг байх.**
20. Энэхүү Стандартын зорилгын хувьд заавал биелүүлэх хэлцэл нь хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адилтгах эрх, үүргийг бий болгодог тохиролцоог илэрхийлнэ.

#### *Хөрөнгийн хяналт*

21. Байгууллага нь тухайн суурь нөөцөөс бий болох ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг авах ба тэрхүү өгөөж болон үйлчилгээний чадавхид бусад этгээд хандан нэвтрэхийг хязгаарлах бүрэн эрхтэй бол хөрөнгийг хянаж байна гэж үзнэ. Биет бус хөрөнгөөс бий болох ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг хянах уг байгууллагын чадвар нь хууль, шүүхийн дагуу хүчин төгөлдөр байх хууль ёсны эрхэд ихэвчлэн үндэслэдэг. Хууль ёсны эрхгүй тохиолдолд хяналтыг нотлон харуулахад нилээд төвөгтэй байдаг. Гэвч байгууллага нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг өөр бусад хэд хэдэн арга замаар хянах боломжтой байж болох учраас эрхийн хууль ёсны хүчин төгөлдөр байдал нь хяналт тавих зайлшгүй шаардлагатай нөхцөл биш юм.
22. Шинжлэх ухааны болон техникийн мэдлэг нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи үүсэхэд хүргэж болох юм. Тухайлбал; уг мэдлэг нь зохиогчийн эрх, худалдааг хязгаарлах хэлцэл (зөвшөөрөгдсөн тохиолдолд) гэх мэт хууль ёсны эрхээр эсвэл нууцыг хадгалах талаар хуулийн дагуу хүлээсэн ажилтнуудын үүргээр хамгаалагдсан байвал байгууллага нь ийм үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг хянаж чадна.
23. Байгууллага нь өндөр ур чадвар бүхий ажилтнуудын багтай бөгөөд сургалт, мэргэшүүлэлтийн үр дүнд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болгох уг ажилтнуудын өсөн нэмэгдэх ур

чадварыг тодорхойлох боломжтой байж болно. Мөн байгууллага нь тэдгээр ажилтнууд өөрсдийн мэргэшсэн ур чадварыг тухайн байгууллагадаа зориулна гэсэн хүлээлттэй байж болох юм. Гэвч уг өндөр ур чадвар бүхий ажилтнуудын “баг”-аас болон тэдгээр ур чадварт зориулсан сургалт, мэргэшүүлэлтээс бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангахын тулд түүнд тухайн байгууллагын тавих хяналт ихэвчлэн хангалтгүй байдаг. Удирдлагын буюу техникийн онцгой авъяасыг ашиглах ба түүнээс бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг авах хууль ёсны эрх хамгаалагдсан бөгөөд биет бус хөрөнгийн тодорхойлолтын бусад нөхцлүүдийг мөн хангаж байхаас бусад тохиолдолд ийм онцгой авъяас нь дээрхтэй адил шалтгаанаар биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй юм.

24. Байгууллага нь өөрийн үйлчилгээний хэрэглэгчдийн багцтай буюу түүний үйлчилгээний зорилтот хэрэглэгчдэд хүрэх амжилтын хувь хэмжээтэй бөгөөд үйлчилгээний хэрэглэгчидтэй харилцаа тогтоох хүчин чармайлтын үр дүнд тэдгээр хэрэглэгч нар түүний үйлчилгээг ашигласан хэвээр байна гэсэн хүлээлттэй байж болох юм. Гэвч үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцаа болон тэдгээр хэрэглэгчдийн үнэнч, тууштай байдлыг хамгаалах хууль ёсны эрх буюу хяналт тавих бусад арга зам байхгүйн улмаас ийм зүйлс (жишээлбэл; үйлчилгээний хэрэглэгчдийн багц, зах зээлийн тодорхой хэсэг буюу үйлчилгээний амжилтын хувь хэмжээ, үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцаа ба тэдгээр хэрэглэгчдийн үнэнч, тууштай байдал) нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангахуйц тийм хангалттай хяналтыг уг байгууллага нь тухайн үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцаанаас болон хэрэглэгчдийн үнэнч, тууштай байдлаас бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид ихэвчлэн тавьж чаддаггүй. Ийм харилцааг хамгаалах хууль ёсны эрх байхгүй тохиолдолд адил буюу ижил төсөөтэй гэрээт бус үйлчлүүлэгчийн харилцаанд хамаарах (нэгдлийн нэг хэсэг байхаас бусад) арилжааны ажил гүйлгээ нь тухайн үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцаанаас бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг уг байгууллага хянах боломжтой хэвээр байна гэсэн нотолгоогоор хангадаг. Ийм арилжааны ажил гүйлгээ нь тухайн үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцааг салган тусгаарлаж болно гэсэн нотолгоогоор бас хангадаг учраас тэдгээр харилцаа нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангана.

*Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи*

25. Биет бус хөрөнгөөс бий болох ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид тухайн байгууллагын бүтээгдэхүүн буюу үйлчилгээний борлуулалтын орлого, өртөг зардлын хэмнэлт буюу хөрөнгийн ашиглалтаас үүсэх бусад үр өгөөж хамаарч болох юм. Жишээлбэл; үйлдвэрлэл буюу үйлчилгээний процессод оюуны өмчийг ашиглах нь ирээдүйн орлогыг нэмэгдүүлэх биш, харин ирээдүйн үйлдвэрлэл буюу үйлчилгээний зардлыг бууруулж, эсвэл үйлчилгээний

нийлүүлэлтийг сайжруулж болох юм (жишээлбэл; жолоочийн үнэмлэхийг он-лайн байдлаар илүү хурдан шинэчлэх боломжийг иргэдэд олгодог он-лайн систем нь боловсруулалтын хурдыг нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр энэхүү чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай оффисын ажилтнуудын тоог цөөрүүлэх үр дүнтэй байдаг).

## Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

26. Биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхийн тулд тухайн зүйл нь дараах шаардлагыг хангаж байгаа гэдгийг нотлон харуулахыг байгууллагаас шаарддаг:

(а) Биет бус хөрөнгийн тодорхойлолт (17-25-р параграфыг үзнэ үү); ба

(б) Хүлээн зөвшөөрөлтийн шалгуур (28-30-р параграфыг үзнэ үү).

Анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн өртөг зардал (биет бус хөрөнгийн арилжааны ажил гүйлгээнд болон биет бус хөрөнгийг дотооддоо бий болгохын тулд гаргасан өртөг зардал эсвэл арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийн бодит үнэ цэнэ), түүнчлэн биет бус хөрөнгийг нэмэгдүүлэх, түүний зарим хэсгийг сольж орлуулах, хэвийн хадгалахын тулд дараагийн тайлант үед гаргасан өртөг зардлын хувьд энэхүү шаардлагыг мөрдөнө.

26А. Энэхүү хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг тусад нь худалдан авсан биет бус хөрөнгөнд мөрдөх талаар 32-39-р параграфт, улсын секторын нэгдлээр олж авсан биет бус хөрөнгөнд мөрдөх талаар 39А-41-р параграфт тус тус авч үзсэн. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийн анхны хэмжилтийн талаар 42-43-р параграфт, биет бус хөрөнгийн солилцооны талаар 44-45-р параграфт, дотооддоо бий болгосон гүүдвиллийн бүртгэлийг 46-48-р параграфт заасан. Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг 49-65-р параграфт авч үзсэн.

27. Ихэнх тохиолдолд биет бус хөрөнгө нь түүнийг нэмэгдүүлэх буюу зарим хэсгийг сольж орлуулах тийм шинж төрөлгүй байдаг. Иймээс дараагийн тайлант үеийн ихэнх зарлага нь энэ Стандартад заасан биет бус хөрөнгийн тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах биш, харин одоо байгаа биет бус хөрөнгийн хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг хадгалах магадлалтай байдаг. Түүнчлэн, дараагийн тайлант үеийн зарлагыг бүхэлдээ тухайн байгууллагын үйл ажиллагаанд биш, харин тодорхой нэг биет бус хөрөнгөнд шууд хамааруулан хуваарилахад ихэвчлэн төвөгтэй байдаг. Иймээс дараагийн тайлант үеийн зарлагыг, өөрөөр хэлбэл олж эзэмшсэн биет бус хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс эсвэл дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн иж бүрдэл болсноос хойш гарсан зарлагыг маш цөөн тохиолдолд уг хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрдөг. Брэнд нэр, сонин хэвлэлийн нүүрэн хэсэгт бичигдэх эрх, хэвлэлийн эрх, үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалт болон эдгээртэй адилтгах шинж чанар бүхий зүйлсийн (гаднаас худалдан авсан эсвэл дотооддоо бий



болгосон эсэхээс үл хамаарна) хувьд дараагийн тайлант үеүдэд гарсан зарлагыг 61-р параграфын дагуу гарсан үед нь ямагт ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Яагаад гэвэл, ийм зарлагыг бүхэлдээ тухайн байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэхэд гаргасан зарлагаас ялган зааглах боломжгүй байдаг.

28. **Биет бус хөрөнгийг зөвхөн дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Тухайн хөрөнгөнд хамаарах хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь уг байгууллагад орох нилээд магадлалтай байх;**
  - (б) **Хөрөнгийн өртөг буюу бодит үнэ цэнийг найдвартай<sup>1</sup> хэмжиж чадах.**
29. **Байгууллага нь тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид оршин байх эдийн засгийн цогц нөхцөл байдлын талаархи удирдлагын хамгийн сайн тооцооллыг илэрхийлэх ул үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц таамаглалыг ашиглан, хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн магадлалыг үнэлнэ.**
30. Байгууллага нь уг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед бэлэн байгаа нотолгоонд үндэслэн тухайн хөрөнгийн ашиглалтанд хамаарах ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн орох магадлалын зэрэг хэмжээг үнэлэхийн тулд шүүн тунгаалт хийдэг. Ингэхдээ гаднын нотолгоонд илүү их ач холбогдол өгнө.
31. **Биет бус хөрөнгийг 32-43-р параграфын дагуу эхлээд өртгөөр нь хэмжинэ. Биет бус хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд энэхүү олж эзэмших үеийн анхны өртгийг тухайн өдрөөрх түүний бодит үнэ цэнээр хэмжинэ.**

#### **Тусад нь худалдаж авах**

32. Биет бус хөрөнгийг тусад нь худалдаж авахын тулд байгууллагын төлөх үнэ нь уг хөрөнгөнд агуулагдсан, хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи тухайн байгууллагад орно гэсэн магадлалын талаархи хүлээлтийг үндсэндээ тусган илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орох хугацаа буюу дүн нь тодорхой бус байсан ч гэсэн тухайн байгууллага нь уг эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орж ирнэ гэж хүлээдэг. Иймээс тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийн хувьд 28(а) параграфт

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

заасан магадлалт хүлээн зөвшөөрөлтийн шалгуур ямагт хангагдана гэж үздэг.

33. Түүнчлэн, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийн өртгийг ихэнх тохиолдолд найдвартай хэмжих боломжтой байдаг. Худалдан авалтын төлбөр нь мөнгө буюу мөнгөн зүйлсийн бусад хөрөнгө хэлбэртэй байх тохиолдолд ихэвчлэн ийм боломжтой байдаг.
34. Тусад нь худалдаж авсан биет бус хөрөнгийн өртөг нь дараах зүйлсээс бүрдэнэ:
- (a) Худалдааны хөнгөлөлт ба хямдруулалтыг хассаны дараах түүний худалдан авалтын үнэ, үүн дотроо импортын татвар болон худалдан авалтын буцаан үл олгогдох татвар; ба
  - (б) Хөрөнгийг түүний зориулалтын дагуу ашиглахад бэлэн болгохтой шууд холбоотой өртөг зардал.
35. Шууд хамаарах өртөг зардлын жишээ нь:
- (a) Тухайн хөрөнгийг түүний ажиллах нөхцөл байдалд оруулахтай шууд холбоотойгоор гарсан ажилтны тэтгэмжийн зардал (УСНББОУС 39-д тодорхойлсноор);
  - (б) Тухайн хөрөнгийг түүний ажиллах нөхцөл байдалд оруулахтай шууд холбоотойгоор гарсан мэргэжлийн үйлчилгээний хөлс; ба
  - (в) Тухайн хөрөнгө зохих ёсоор ажиллаж байгаа эсэхийг сорьж шалгах зардал.
36. Биет бус хөрөнгийн өртгийн нэг хэсэг болохгүй зардлын жишээ нь:
- (a) Шинэ бүтээгдэхүүн буюу үйлчилгээг танилцуулах зардал (үүнд: зар сурталчилгаа ба урамшууллын үйл ажиллагааны зардал);
  - (б) Шинэ байрлалд эсвэл үйлчилгээний хэрэглэгчдийн шинэ бүлэгтэй үйл ажиллагаа эхлүүлэн явуулахад гарах зардал (үүнд ажилтнуудын сургалтын зардал); ба
  - (в) Захиргааны болон бусад ерөнхий удирдлагын нэмэгдэл зардал.
37. Удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай нөхцөл байдалд уг хөрөнгийг авчирсан тохиолдолд өртөг зардлыг тухайн биет бус хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрөхийг зогсооно. Иймээс биет бус хөрөнгийг ашиглах эсвэл өөр байршилд шилжүүлэхэд гаргасан өртөг зардлыг тухайн хөрөнгийн дансны үнэд оруулахгүй. Тухайлбал; дараах өртөг зардлуудыг биет бус хөрөнгийн дансны үнэд тусган оруулахгүй:
- (a) Удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болсон хөрөнгө нь ашиглалтанд хараахан ороогүй байх үед гарсан өртөг зардал;

- (б) Тухайн хөрөнгөөр хийгдэх бүтээгдэхүүний эрэлт бий болох явцад гарсан өртөг зардал гэх мэт үйл ажиллагааны эхлэлийн шатны алдагдал.
38. Зарим үйл ажиллагаа нь биет бус хөрөнгийн хөгжүүлэлттэй холбоотойгоор гарч тохиолддог боловч удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм нөхцөл байдалд уг хөрөнгийг авчрахад зайлшгүй шаардлагатай биш байдаг. Ийм туслах үйл ажиллагаа нь хөгжүүлэлтийн үе шатны явцад эсвэл түүнээс өмнө гарч тохиолдож болох юм. Энэхүү туслах үйл ажиллагаа нь удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм нөхцөл байдалд уг хөрөнгийг авчрахад зайлшгүй шаардлагатай биш тул уг туслах үйл ажиллагааны орлого болон холбогдох зардлыг ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрч, тэдгээр орлого, зардлын тус тусын ангилалд хамруулан тусгана.
39. Хэрэв биет бус хөрөнгийн төлбөрийг зээлийн хэвийн хугацаанаас илүүгээр хойшлуулвал түүний өртөг нь мөнгөн үнэтэй адилтгах дүн байна. Энэхүү дүн ба нийт төлбөрийн хоорондох зөрүүг УСНББОУС 5, *Зээлийн Өртөг*-ийн дагуу капиталжуулахаас бусад тохиолдолд уг зээлийн хугацаанд хүүний зардал гэж хүлээн зөвшөөрнө.

**Нэгдлийн (улсын секторын нэгдлийн) нэг хэсэг байдлаар биет бус хөрөнгийг олж эзэмших**

- 39А. УСНББОУС 40-ийн дагуу хэрэв биет бус хөрөнгийг нэгдлээр олж эзэмшсэн бол уг биет бус хөрөнгийн өртөг нь тухайн нэгдлийн өдрөөрх түүний бодит үнэ цэнэ байна. Биет бус хөрөнгийн бодит үнэ цэнэ нь тухайн хөрөнгөнд агуулагдсан, хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи уг байгууллагад орох магадлалын талаархи тэрхүү нэгдлийн өдрөөрх зах зээлд оролцогчдын хүлээлтийг тусгадаг. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орох хугацаа буюу дүн нь тодорхой бус байлаа ч гэсэн тухайн байгууллага нь уг эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орж ирнэ гэж хүлээдэг. Иймээс нэгдлээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийн хувьд 28(а) параграфт заасан магадлалт хүлээн зөвшөөрөлтийн шалгуур ямагт хангагдана гэж үздэг. Хэрэв нэгдлээр олж эзэмшсэн хөрөнгө нь тусдаа салгах боломжтой эсвэл заавал биелүүлэх хэлцлээс (үүн дотроо, гэрээний буюу хуулийн бусад эрхээс) үүссэн бол уг хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих хангалттай мэдээлэл оршин байдаг. Иймээс нэгдлээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийн хувьд 28(б) параграфт заасан найдвартай хэмжилтийн шалгуур ямагт хангагдана гэж үзнэ.
- 39Б. Худалдан авсан үйл ажиллагаагаар тухайн хөрөнгийг нэгдлээс өмнө хүлээн зөвшөөрч байсан эсэхээс үл хамааран нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааны биет бус хөрөнгийг энэхүү Стандарт болон УСНББОУС 40-ийн дагуу тэрхүү нэгдлийн өдрөөр гүүдвилээс тусад нь хүлээн зөвшөөрнө. Хэрэв уг худалдан авсан үйл ажиллагааны дуусаагүй судалгаа ба хөгжүүлэлтийн төсөл нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангаж байвал тухайн нэгтгэгч түүнийг гүүдвилээс тусад нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө

гэсэн утгатай заалт юм. Худалдан авсан үйл ажиллагааны дуусаагүй судалгаа ба хөгжүүлэлтийн төсөл нь дараах тохиолдолд биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангана:

- (а) Хөрөнгийн тодорхойлолтыг хангах; ба
- (б) Тодорхойлж болох, өөрөөр хэлбэл, салган тусгаарлаж болох эсвэл заавал биелүүлэх хэлцлээс (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхээс) үүссэн байх.

*Нэгдлээр (улсын секторын нэгдлээр) олж эзэмшсэн биет бус хөрөнгө*

- 39В. Хэрэв нэгдлээр олж эзэмшсэн биет бус хөрөнгө нь салган тусгаарлаж болох эсвэл заавал биелүүлэх хэлцлээс (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхээс) үүссэн бол тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих хангалттай мэдээлэл оршин байдаг. Биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан тооцооллын хувьд өөр өөр магадлал бүхий хэд хэдэн боломжит үр дүнгүүд байвал тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтэнд энэхүү тодорхой бус байдал нөлөөлнө.
- 39Г. Нэгдлээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийг гүүдвилээс салган тусгаарлаж болох боловч зөвхөн холбогдох заавал биелүүлэх хэлцэл, тодорхойлж болох хөрөнгө буюу өр төлбөрийн хамтаар салган тусгаарлах боломжтой байж болно. Ийм тохиолдолд нэгтгэгч нь биет бус хөрөнгийг гүүдвилээс тусдаа боловч холбогдох зүйлсийн хамтаар хүлээн зөвшөөрнө.
- 39Д. Бие даасан хөрөнгүүд нь төсөөтэй ашиглалтын хугацаатай бол нэгтгэгч нь харилцан бие биенийхээ гүйцээлт болох биет бус хөрөнгүүдийн бүлгийг нэг хөрөнгө мэтээр хүлээн зөвшөөрч болно. Жишээлбэл; 'брэнд' ба 'брэндийн нэр' гэсэн нэр томъёог худалдааны тэмдэг ба бусад тэмдэгтэй ихэвчлэн ижил төсөөтэй утгаар хэрэглэдэг. Гэхдээ 'брэнд' гэдэг нь худалдааны тэмдэг (буюу үйлчилгээний тэмдэг) ба түүний холбогдох худалдааны нэр, томъёолол, жор, технологийн туршлага чадвар гэх мэт харилцан бие биенийхээ гүйцээлт болох хөрөнгүүдийн бүлгийг илэрхийлэхэд нийтлэг ашиглагддаг маркетингийн ерөнхий нэр томъёо юм.

**Олж эзэмшсэн дуусаагүй судалгаа ба хөгжүүлэлтийн төслийн дараагийн тайлант үеийн зарлага**

- 40. **Дараах судалгаа буюу хөгжүүлэлтийн зарлагыг 52-60-р параграфын дагуу тайлагнана:**
  - (а) **Тусад нь, эсвэл нэгдлээр олж эзэмшсэн бөгөөд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн, дуусаагүй судалгаа буюу хөгжүүлэлтийн төсөлд хамаарах; ба**
  - (б) **Тухайн төслийг худалдан авсны дараа гарсан байх.**
- 41. 52-60-р параграфуудын шаардлагуудыг мөрдөнө гэдэг бол тусад нь, эсвэл нэгдлээр олж эзэмшсэн бөгөөд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн, дуусаагүй судалгаа буюу хөгжүүлэлтийн төслийн хувьд гарсан дараагийн тайлант үеийн зарлагыг дараах байдлаар тусгахыг хэлнэ. Үүнд:

- (а) Хэрэв судалгааны зарлага бол түүнийг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрөх;
- (б) Хэрэв 55-р параграфт заасан, биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй хөгжүүлэлтийн зарлага бол түүнийг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрөх; ба
- (в) Хэрэв 55-р параграфт заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах хөгжүүлэлтийн зарлага бол түүнийг уг олж эзэмшсэн, дуусаагүй судалгаа буюу хөгжүүлэлтийн төслийн дансны үнэ дээр нэмэх.

### **Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биет бус хөрөнгө**

- 42. Зарим тохиолдолд, биет бус хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшиж болно. Улсын секторын өөр нэг байгууллага нь нисэх онгоцны буудалд онгоц газардуулах эрх, радио буюу телевизийн станцыг ажиллуулах зөвшөөрөл, импортын лиценз буюу квот, бусад хязгаарлагдсан нөөцөд хандан нэвтрэх эрх гэх мэт биет бус хөрөнгийг тухайн байгууллагад арилжааны бус ажил гүйлгээгээр шилжүүлсэн үед ийм тохиолдол үүсэж болох юм. Хувь хүн, жишээлбэл Нобелийн шагнал хүртэгч нь хувийн баримт бичгийг, үүн дотроо өөрийн хэвлэлийн зохиогчийн эрхийг арилжааны бус ажил гүйлгээгээр үндэсний архивт (улсын секторын байгууллагад) гэрээслэн өгч болох юм.
- 43. Ийм нөхцөл байдалд тухайн зүйлийн өртөг нь уг олж эзэмшсэн өдрөөрх түүний бодит үнэ цэнэ байна. Энэ Стандартын зорилгын хувьд, арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед 74-р параграфын шаардлагуудын дагуу түүний бодит үнэ цэнээр хийх хэмжилт нь дахин үнэлгээг орлохгүй юм. Иймээс байгууллага нь дараагийн тайлант үед биет бус зүйлийг дахин үнэлэх сонголт хийсэн зөвхөн тийм тохиолдолд 74-р параграфт заасан дахин үнэлгээний шаардлага болон 75-86-р параграфт заасан дэмжих тайлбар зөвлөмжийг мөрдөнө.

### **Хөрөнгийн солилцоо**

- 44. Мөнгөн бус зүйлсийн хөрөнгө буюу хөрөнгүүд, эсвэл мөнгө зүйлсийн болон мөнгөн бус зүйлсийн хөрөнгийн аль алиныг оролцуулсан солилцоогоор нэг буюу хэд хэдэн биет бус хөрөнгүүдийг олж авч болно. Дараах тайлбар хэлэлцүүлэг нь зөвхөн нэг мөнгөн бус зүйлсийн хөрөнгийг өөр нэг мөнгөн бус зүйлсийн хөрөнгөөр солилцох талаар авч үзсэн боловч өмнөх өгүүлбэрт дурдсан бүх солилцооны хувьд мөн адил хамаарна. Хүлээн авсан хөрөнгө эсвэл өгсөн хөрөнгийн аль алины бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй тохиолдолд ийм биет бус хөрөнгийн өртгийг бодит үнэ цэнээр хэмжинэ. Хэдийгээр байгууллага нь өгөх хөрөнгийг тэр даруйд үл хүлээн зөвшөөрөх боломжгүй байлаа ч гэсэн тухайн авах хөрөнгийг ийм байдлаар хэмжинэ. Хэрэв олж авсан хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжих боломжгүй бол түүний өртгийг тухайн өгсөн хөрөнгийн дансны үнээр хэмжинэ.

45. Биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөх нөхцөл нь уг хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой байдал гэдгийг 28(б) параграфт тусгайлан заасан байдаг. Зэрэгцүүлэгдэх зах зээлийн ажил гүйлгээ байхгүй биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийг зөвхөн дараах тохиолдолд найдвартай хэмжих боломжтой байна.

- (а) Бодит үнэ цэнийн ул үндэслэлтэй хэмжилтийн муж доторх хувьсан өөрчлөлт нь тухайн хөрөнгийн хувьд мэдэгдэхүйц дүнтэй биш байх, эсвэл;
- (б) Уг мужийн доторх янз бүрийн тооцооллуудын магадлалыг ул үндэслэлтэйгээр үнэлж болох бөгөөд бодит үнэ цэнийг хэмжихдээ ашиглах боломжтой байх.

Хэрэв байгууллага нь хүлээн авсан хөрөнгө эсвэл өгсөн хөрөнгийн аль алины бодит үнэ цэнийг найдвартайгаар хэмжих боломжтой байвал уг хүлээн авсан хөрөнгийн бодит үнэ цэнэ илт тодорхой байхаас бусад тохиолдолд өртгийг хэмжихдээ тэрхүү өгсөн хөрөнгийн бодит үнэ цэнийг ашиглана.

#### **Дотооддоо бий болгосон гүүдвил**

46. **Дотооддоо бий болгосон гүүдвیلیйг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй.**

47. Зарим тохиолдолд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг бий болгохын тулд зарлага гаргадаг боловч уг зарлага нь энэ Стандартад заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах биет бус хөрөнгө үүсгэх үр дагаваргүй байдаг. Ийм зарлагыг дотооддоо бий болгосон гүүдвилд хувь нэмрээ оруулж байна гэж ихэвчлэн тодорхойлдог. Дотооддоо бий болгосон гүүдвил нь тухайн байгууллага хянаж, өртгийг нь найдвартай хэмжиж чадах, тийм тодорхойлж болох нөөц биш (өөрөөр хэлбэл, үүнийг салган тусгаарлах боломжгүй, мөн заавал биелүүлэх хэлцлээс (гэрээний буюу бусад хуулийн эрхээс) үүсээгүй) учраас түүнийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөггүй.

48. Аливаа хугацаан дахь тухайн байгууллагын зах зээлийн үнэ ба түүний тодорхойлж болох цэвэр хөрөнгүүдийн дансны үнийн хоорондох зөрүү нь уг байгууллагын үнэ цэнэд нөлөөлөх олон хүчин зүйлсийг тусгаж болох юм. Гэхдээ ийм зөрүү нь уг байгууллагын хянаж буй биет бус хөрөнгийн өртгийг илэрхийлдэггүй.

#### **Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө**

49. Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө нь дараах тохиолдолд үүсэх асуудлуудын улмаас хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж буй эсэхийг зарим үед үнэлэхэд төвөгтэй байдаг:

- (а) Хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг бий болгох тийм тодорхойлж болох хөрөнгө байгаа эсэх болон хэзээ байх эсэхийг тогтоох;

- (б) Хөрөнгийн өртгийг найдвартай тодорхойлох. Биет бус хөрөнгийг дотооддоо бий болгох өртөг зардлыг уг байгууллагын дотооддоо бий болгосон гүүдвилийг хэвийн хадгалах буюу сайжруулах, эсвэл өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах өртөг зардлаас зарим үед ялган зааглах боломжгүй байдаг.

Иймээс байгууллага нь биет бус хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба анхны хэмжилтийн ерөнхий шаардлагуудыг даган мөрдөхөөс гадна дотооддоо бий болгосон бүх биет бус хөрөнгийн хувьд 50-65-р параграфт заасан шаардлагууд болон заавар удирдамжийг мөрдөнө.

50. Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж буй эсэхийг үнэлэхийн тулд байгууллага нь хөрөнгийн үүсгэн бий болголтыг дараах байдлаар ангилна:

(а) Судалгааны үе шат; ба

(б) Хөгжүүлэлтийн үе шат.

Хэдийгээр “судалгаа” ба “хөгжүүлэлт” нэр томъёонуудыг тодорхойлсон боловч “судалгааны үе шат”, “хөгжүүлэлтийн үе шат” нэр томъёонууд нь энэ Стандартын зорилгын хувьд илүү өргөн утгатай байна.

51. Хэрэв байгууллага нь биет бус хөрөнгийг үүсгэн бий болгох өөрийн дотоодын төслийн судалгааны үе шатыг хөгжүүлэлтийн үе шатнаас ялган зааглаж чадахгүй бол уг байгууллага нь тухайн төслийн зарлагыг зөвхөн судалгааны үе шатанд гарсан мэтээр авч үзнэ.

#### *Судалгааны үе шат*

52. **Судалгаанаас (буюу дотоодын төслийн судалгааны үе шатнаас) үүсэх биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй. Судалгааны (буюу дотоодын төслийн судалгааны үе шатны) зарлагыг түүний гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.**

53. Дотоодын төслийн судалгааны үе шатанд байгууллага нь ирээдүйн магадлалт эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг бий болгох биет бус хөрөнгө оршин байгаа гэдгийг батлан харуулж чадахгүй. Иймээс энэхүү үе шатны зарлагыг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.

54. Судалгааны үйл ажиллагааны жишээ нь:

(а) Шинэ мэдлэг олж авах зорилго бүхий үйл ажиллагаа;

(б) Судалгааны үр дүн буюу бусад мэдлэгийг эрж хайх, үнэлэх, эцсийн сонголт хийх, ашиглах үйл ажиллагаа;

(в) Материал, төхөөрөмж, бүтээгдэхүүн, процесс, систем буюу үйлчилгээний боломжит хувилбаруудын талаархи эрэл хайгуул;

(г) Шинэ буюу сайжруулсан материал, төхөөрөмж, бүтээгдэхүүн, процесс, систем буюу үйлчилгээний боломжит хувилбаруудын томъёолол, зохиомж, үнэлгээ, эцсийн сонголт.

*Хөгжүүлэлтийн үе шат*

55. **Байгууллага нь дараах бүх зүйлсийг батлан харуулж чадах зөвхөн тийм тохиолдолд хөгжүүлэлтээс (буюу дотоодын төслийн хөгжүүлэлтийн үе шатнаас) бий болох биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө:**
- (a) **Биет бус хөрөнгийг ашиглах эсвэл борлуулах боломжтой байхын тулд түүнийг бүрэн дуусгах техникийн үндэслэлтэй байх;**
  - (б) **Биет бус хөрөнгийг бүрэн дуусгах ба түүнийг ашиглах эсвэл борлуулах өөрийн санаа зорилго;**
  - (в) **Биет бус хөрөнгийг ашиглах эсвэл борлуулах өөрийн чадвар боломж;**
  - (г) **Биет бус хөрөнгө нь ирээдүйн магадлалт эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг хэрхэн бий болгох. Бусад зүйлсээс гадна байгууллага нь уг биет бус хөрөнгийн гарц бүтээгдэхүүний буюу тэрхүү биет бус хөрөнгийн өөрийнх нь хувьд зах зээл оршин байгаа гэдгийг, хэрэв биет бус хөрөнгийг дотооддоо ашиглах бол тухайн биет бус хөрөнгө ач тустай гэдгийг батлан харуулна;**
  - (д) **Хөгжүүлэлтийг бүрэн дуусгах ба тухайн биет бус хөрөнгийг ашиглах эсвэл борлуулах зохих техникийн, санхүүгийн болон бусад нөөцүүд бэлэн боломжтой байх;**
  - (е) **Хөгжүүлэлтийн явцад уг биет бус хөрөнгөнд хамаарах зарлагыг найдвартай хэмжих өөрийн чадвар боломж.**
56. **Зарим тохиолдолд байгууллага нь дотоодын төслийн хөгжүүлэлтийн үе шатанд биет бус хөрөнгийг тодорхойлох ба уг хөрөнгө ирээдүйн магадлалт эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг бий болгоно гэдгийг батлан харуулж чаддаг. Яагаад гэвэл төслийн хөгжүүлэлтийн үе шат нь судалгааны үе шатнаас илүү ахиц гаргасан байдаг.**
57. **Хөгжүүлэлтийн үйл ажиллагааны жишээ нь:**
- (a) **Үйлдвэрлэлийн өмнөх эсвэл ашиглалтын өмнөх эх загвар болон моделийн зохиомжийг гаргах, барьж байгуулах, сорьж турших ажиллагаа;**
  - (б) **Шинэ технологитой холбоотой багаж, хэв, цутгалт, өнгө будгийн зохиомжийг гаргах ажиллагаа;**
  - (в) **Арилжааны үйлдвэрлэл явуулах буюу үйлчилгээ үзүүлэхэд ашиглах цар хүрээ бүхий эдийн засгийн үндэслэлтэй биш тийм туршилтын үйлдвэр болон үйл ажиллагааны зохиомжийг гаргах, түүнийг барьж байгуулах ба ажиллуулах үйл ажиллагаа;**



- (г) Шинэ буюу сайжруулсан материал, төхөөрөмж, бүтээгдэхүүн, процесс, систем буюу үйлчилгээний сонгосон хувилбарын зохиомжийг гаргах, барьж байгуулах, сорьж турших ажиллагаа;
- (д) Вэб сайтын өртөг ба программ хангамж боловсруулалтын өртөг.
58. Биет бус хөрөнгө нь ирээдүйн магадлалт эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг хэрхэн бий болгохыг батлан харуулахын тулд байгууллага нь тухайн хөрөнгөөс хүлээн авах ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* эсвэл УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын аль тохиромжтойд заасан зарчмуудыг ашиглан үнэлнэ. Хэрэв уг биет бус хөрөнгө нь зөвхөн бусад хөрөнгүүдтэй нэгдэн хосолсноор эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг бий болгохоор байвал байгууллага нь УСНББОУС 26-д заасан, мөнгө бий болгогч нэгжүүдийн талаархи ойлголт, ухагдахууныг баримтална.
59. Биет бус хөрөнгийг бүрэн дуусгах, ашиглах, түүнээс үр өгөөж олж авах нөөцийн бэлэн боломжтой байдлыг тухайлбал, үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр батлан харуулж болно. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь шаардлагатай техникийн, санхүүгийн болон бусад нөөцүүд, түүнчлэн тэдгээр нөөцүүдийг олж авах уг байгууллагын чадвар, боломжийг харуулдаг. Зарим тохиолдолд байгууллага нь уг төлөвлөгөөг санхүүжүүлэхэд бэлэн байгаа гэсэн зээлдүүлэгчийн буюу санхүүжүүлэгчийн мэдэгдлийг олж авснаар гаднын санхүүжилтийн бэлэн, боломжтой байдлыг батлан харуулдаг.
60. Байгууллагын өртөг тооцох систем нь лого, зохиогчийн эрх, лицензийг олж авах, эсвэл компьютерийн программ хангамжийг боловсруулахад гарах цалингийн болон бусад зардал гэх мэт биет бус хөрөнгийг дотооддоо бий болгох өртөг зардлыг ихэвчлэн найдвартай хэмжиж чаддаг.
61. **Дотооддоо бий болгосон брэнд нэр, сонин хэвлэлийн нүүрэн хэсэгт бичигдэх эрх, хэвлэлийн эрх, үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалт болон эдгээртэй адилтгах шинж чанар бүхий зүйлсийг биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй.**
62. Дотооддоо бий болгосон брэнд нэр, сонин хэвлэлийн нүүрэн хэсэгт бичигдэх эрх, хэвлэлийн эрх, үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалт болон эдгээртэй адилтгах шинж чанар бүхий зүйлсийн хувьд гарсан зарлагыг бүхэлдээ тухайн байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэх өртөг зардлаас ялган зааглаж чадахгүй. Иймээс эдгээр зүйлсийг биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй.

*Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн өртөг*

63. 31-р параграфт заасан зорилгын хувьд, тухайн дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн өртөг нь уг биет бус хөрөнгө 28, 29, 55-р параграф дахь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг анх хангасан өдрөөс хойш гарсан

зарлагуудын нийлбэр байна. Зардал гэж өмнө нь хүлээн зөвшөөрсөн зарлагуудыг буцааж өртөгт оруулахыг 70-р параграфтаар хориглосон байдаг.

64. Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн өртөг нь удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгохын тулд уг хөрөнгийг бүтээх, үйлдвэрлэх, бэлтгэхэд шаардлагатай, шууд хамааруулж болох бүх өртөг зардлуудаас бүрдэнэ. Шууд хамаарах өртөг зардлын жишээ нь:
- (а) Биет бус хөрөнгийг бий болгоход ашигласан буюу зарцуулсан материал ба үйлчилгээний өртөг;
  - (б) Биет бус хөрөнгийг бий болгосноор гарах ажилтны тэтгэмжийн зардал (УСНББОУС 39-д тодорхойлсоны дагуу);
  - (в) Хууль ёсны эрхийг бүртгүүлэх хураамж; ба
  - (г) Биет бус хөрөнгийг бий болгоход ашигласан патент, лицензийн хорогдуулгын зардал.

Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн өртгийн элемент байдлаар хүүний зардлыг хүлээн зөвшөөрөх шалгуурыг УСНББОУС 5-д тусгайлан заасан байдаг.

65. Дараах зүйлс нь дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн өртгийн бүрэлдэхүүн хэсэг биш юм:
- (а) Хөрөнгийг түүний зориулалтын дагуу ашиглахад бэлэн болгохтой шууд холбоотой байхаас бусад тохиолдолд борлуулалтын, захиргааны болон бусад ерөнхий удирдлагын нэмэгдэл зардал;
  - (б) Тухайн хөрөнгө нь төлөвлөсөн гүйцэтгэлд хүрэхийн өмнөх тогтоосон үр ашиггүй байдал болон үйл ажиллагааны эхний алдагдал; ба
  - (в) Уг хөрөнгийг ажиллуулах ажилтны сургалтын зардал.

### **Зардлын хүлээн зөвшөөрөлт**

66. **Доор дурдснаас бусад тохиолдолд биет бус зүйлсийн хувьд гарсан зарлагыг түүний гарсан үед зардал гэж хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Энэ нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах биет бус хөрөнгийн өртгийн нэг хэсгийг бүрдүүлэх (26-65-р параграфыг үзнэ үү); эсвэл**
  - (б) **Тухайн зүйлийг нэгдлээр олж авсан бөгөөд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй байх. Ийм тохиолдолд уг зүйл нь тухайн нэгдлийн өдрөөр гүүдвил гэж хүлээн зөвшөөрсөн дүнгийн нэг хэсгийг бүрдүүлнэ (УСНББОУС 40-ийг үзнэ үү).**
67. Зарим тохиолдолд байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүрдүүлэхийн тулд зарлагыг гаргадаг боловч хүлээн

зөвшөөрч болох биет бус хөрөнгө буюу бусад хөрөнгийг олж авдаггүй эсвэл үүсгэн бий болгодоггүй. Барааны нийлүүлэлтийн хувьд байгууллага нь тухайн барааг захиран зарцуулах эрхтэй болсон үед ийм зарлагыг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Харин үйлчилгээний нийлүүлэлтийн хувьд байгууллага нь тухайн үйлчилгээг хүлээн авсан үед уг зарлагыг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; нэгдлийн нэг хэсэг байдлаар олж авснаас бусад тохиолдолд судалгааны ажлын зарлагыг түүний гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө (52-р параграфыг үзнэ үү). Гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрөх зарлагын бусад жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) УСНББОУС 17-гийн дагуу үндсэн хөрөнгийн өртөгт оруулснаас бусад тохиолдолд гарааны үйл ажиллагааны зарлага (өөрөөр хэлбэл, гарааны зардал). Гарааны зардал нь хуулийн этгээдийг үүсгэн байгуулахтай холбоотойгоор гарсан хуулийн болон бичиг хэргийн зардал, шинэ байгууламж буюу үйл ажиллагааг нээх зардал (өөрөөр хэлбэл, нээлтийн өмнөх зардал), шинэ үйл ажиллагааг эхлүүлэх эсвэл шинэ бүтээгдэхүүн буюу процессыг нэвтрүүлэх зардлаас (өөрөөр хэлбэл, нээлтийн өмнөх зардал) бүрдэж болох юм.
- (б) Сургалтын үйл ажиллагааны зарлага.
- (в) Зар сурталчилгааны болон идэвхижүүлэлтийн үйл ажиллагааны зарлага (үүнд: захиалгын катологи болон мэдээллийн товхимолыг шуудангаар илгээх зардал хамаарна).
- (г) Байгууллагын бүх буюу зарим хэсгийг нүүлгэн шилжүүлэх эсвэл дахин зохион байгуулах зарлага.

68. Байгууллага нь барааг өмчлөх үед түүнийг захиран зарцуулах эрхтэй болдог. Үүнтэй адилаар, нийлүүлэгч нь нийлүүлэлтийн гэрээний дагуу барааг үйлдвэрлэж, бий болгосон бөгөөд байгууллага нь өөрийн төлбөрийн хариуд уг барааг хүргэн нийлүүлэхийг шаардах боломжтой болсон үед тухайн байгууллага нь барааг захиран зарцуулах эрхтэй болдог. Тухайн байгууллагад үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу нийлүүлэгч нь үйлчилгээг үзүүлсэн үед уг үйлчилгээг хүлээн авсан гэж үзнэ. Харин тухайн байгууллага нь өөр нэг үйлчилгээг үзүүлэх, тухайлбал; худалдан авагчдад зар сурталчилгааг хүргэхийн тулд уг үйлчилгээг хэзээ ашиглах эсэхээс хамаарахгүй.

69. Тухайн байгууллага нь барааг захиран зарцуулах эрхтэй болохын өмнө уг барааны төлбөрийг урьдчилан төлсөн тохиолдолд тэрхүү урьдчилгаа төлбөрийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхөд 66-р параграф саад учруулахгүй. Үүнтэй адилаар, байгууллага нь үйлчилгээг авахын өмнө уг үйлчилгээний төлбөрийг урьдчилан төлсөн тохиолдолд тэрхүү урьдчилгаа төлбөрийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхөд 66-р параграф саад учруулахгүй.

**Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй өнгөрсөн зардлууд**

70. Энэ Стандартын дагуу зардал гэж анх хүлээн зөвшөөрсөн биет бус зүйлсийн хувьд гарсан зарлагыг хожим нь биет бус хөрөнгийн өртгийн нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрөхгүй.

**Дараагийн тайлант үеийн хэмжилт**

71. Байгууллага нь 73-р параграфт заасан өртгийн загвар, 74-р параграфт заасан дахин үнэлгээний загварын аль нэгийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого болгон сонгоно. Хэрэв биет бус хөрөнгийг дахин үнэлгээний загвар ашиглан тайлагнадаг бол түүний ангийн хөрөнгүүдийн хувьд идэвхитэй зах зээл байхгүй байхаас бусад тохиолдолд уг ангийн бусад бүх хөрөнгүүдийг мөн адил дахин үнэлгээний загвар ашиглан тайлагнана.
72. Биет бус хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдлын хувьд ижил төсөөтэй шинж төрөл ба хэрэглээ бүхий хөрөнгүүдийн бүлэг юм. Хөрөнгүүдээс сонголт хийж дахин үнэлэх, түүнчлэн өөр өөр хугацааны өртөг ба дахин үнэлсэн үнэ цэнийг хольж, санхүүгийн тайланд тусгахаас сэргийлэхийн тулд биет бус хөрөнгийн нэг анги доторх зүйлсийг нэгэн зэрэг дахин үнэлнэ.

**Өртгийн загвар**

73. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа биет бус хөрөнгийг өртгөөс түүний аливаа хуримтлагдсан хорогдуулга ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэж, тусгана.

**Дахин үнэлгээний загвар**

74. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа биет бус хөрөнгийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, тусгана. Энэ нь тухайн хөрөнгийн дахин үнэлгээний өдрөөрх бодит үнэ цэнээс түүний дараагийн тайлант үеийн аливаа хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүн байна. Энэ Стандартад заасан дахин үнэлгээний зорилгоор, идэвхитэй зах зээлийн үнийг лавлагаа болгосноор бодит үнэ цэнийг тодорхойлно. Тухайн тайлагналын үеийн эцэс дэх уг хөрөнгийн дансны үнэ нь түүний бодит үнэ цэнээс материаллаг зөрүүгүй байх тийм давтамжтайгаар дахин үнэлгээг хийнэ.
75. Дахин үнэлгээний загвар нь дараах зүйлсийг зөвшөөрдөггүй:
- (а) Өмнө нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөөгүй биет бус хөрөнгийг дахин үнэлэх; эсвэл
  - (б) Биет бус хөрөнгийг өртгөөс өөр дүнгээр анх хүлээн зөвшөөрөх.
76. Хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрсний дараа дахин үнэлгээний загварыг хэрэглэнэ. Гэвч нийт процессын тодорхой нэг хэсэг хүртэл уг хөрөнгө нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй (63-р параграфыг

үзнэ үү) тул биет бус хөрөнгийн өртгийн зөвхөн зарим хэсгийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн боловч дахин үнэлгээний загварыг тухайн хөрөнгөнд бүхэлд нь хэрэглэж болох юм. Арилжааны бус ажил гүйлгээгээр хүлээн авсан биет бус хөрөнгийн хувьд мөн дахин үнэлгээний загварыг хэрэглэж болно (42-43-р параграфыг үзнэ үү).

77. Биет бус хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээл оршин байж болох боловч тийм ч түгээмэл бус байдаг. Жишээлбэл; зарим улс оронд байгууллага нь өөр нэг байгууллагаас олж эзэмшсэн, чөлөөтэй шилжүүлж болох нэг ижил төрлийн ангийн лиценз буюу үйлдвэрлэлийн квотын хувьд идэвхитэй зах зээл оршин байж болно. Харин брэнд нэр, сонин хэвлэлийн нүүрэн хэсэгт бичигдэх эрх, хөгжим болон киног нийтлэх эрх, патент, худалдааны тэмдэг гэх мэт биет бус хөрөнгийн өвөрмөц онцлогоос хамааран тэдгээрийн хувьд идэвхитэй зах зээл оршин байдаггүй байж болох юм. Мөн биет бус хөрөнгийг худалдан авах буюу борлуулж, тухайн тодорхой худалдан авагч ба борлуулагчдын хооронд гэрээ хэлцэл хийгддэг боловч ийм ажил гүйлгээ харьцангуй түгээмэл бус байдаг. Эдгээр шалтгааны улмаас нэг биет бус хөрөнгийн хувьд төлсөн үнэ нь өөр нэг биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийн талаархи хангалттай нотолгоо болж чадахгүй байж болно. Түүнчлэн, үнэ нь олон нийтэд ихэвчлэн нээлттэй, ил тод байдаггүй.
78. Дахин үнэлгээ хийх давтамж нь уг дахин үнэлж буй биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хувьсан өөрчлөлтөөс хамаардаг. Дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллагаар өөр болсон тохиолдолд дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай байдаг. Зарим биет бус хөрөнгө нь бодит үнэ цэнийн мэдэгдэхүйц ба эрс огцом хувьсан өөрчлөлтөнд өртдөг тул жил бүр дахин үнэлгээ хийх шаардлагатай болдог. Бодит үнэ цэнэд нь ялимгүй бага өөрчлөлт ордог биет бус хөрөнгийн хувьд ингэж ойр ойрхон дахин үнэлгээ хийх шаардлагагүй юм.
79. Биет бус хөрөнгийг дахин үнэлсэн тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг уг дахин үнэлсэн дүн болгож тохируулна. Тухайн хөрөнгийг дахин үнэлгээний өдөр доор дурдсан аргын аль нэгээр өөрчлөн бүртгэнэ:
- (а) Тухайн хөрөнгийн дансны үнийн хувьд хийсэн дахин үнэлгээтэй нийцэх тийм байдлаар нийт дансны үнийг тохируулна. Тухайлбал; зах зээлийн ажиглаж болох мэдээг лавлагаа болгосноор эсвэл дансны үнийн өөрчлөлттэй хувь тэнцүүлэх байдлаар (пропорциональ хамааралтайгаар) нийт дансны үнийг дахин тайлагнаж болно. Хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг харгалзсаны дараах уг хөрөнгийн дансны үнэ ба нийт дансны үнийн хоорондох зөрүүг тэнцүүлэхийн тулд тэрхүү дахин үнэлгээний өдрөөрх хуримтлагдсан хорогдуулгыг тохируулна; эсвэл
  - (б) Хуримтлагдсан хорогдуулгыг тухайн хөрөнгийн нийт дансны үнээс хасна.

Хуримтлагдсан хорогдуулгад хийх тохируулгын дүн нь 84 ба 85-р параграфын дагуу тайлагнасан уг дансны үнийн өсөлт эсвэл бууралтын нэг хэсэг болно.

80. Дахин үнэлсэн биет бус хөрөнгийн анги дахь тодорхой нэг биет бус хөрөнгийг түүний идэвхитэй зах зээл байхгүйн улмаас дахин үнэлж чадаагүй бол тэрхүү хөрөнгийг түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга ба үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тусгана.
81. Дахин үнэлсэн биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийг идэвхитэй зах зээлийн үнийг лавлагаа болгосноор цаашид хэмжих боломжгүй байвал уг хөрөнгийн дансны үнэ нь идэвхитэй зах зээлийн үнийг лавлагаа болгосноор тодорхойлсон хамгийн сүүлийн дахин үнэлгээний өдрөөрх түүний дахин үнэлсэн дүнгээс аливаа дараагийн тайлант үеийн хуримтлагдсан хорогдуулга ба аливаа дараагийн тайлант үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байна.
82. Дахин үнэлсэн биет бус хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээл цаашид оршин байхгүй болж буй нь уг хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох бөгөөд УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой нэг стандартын дагуу үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах шаардлагатай гэдгийг илэрхийлж болох юм.
83. Хэрэв дараагийн тайлант үеүдийн хэмжилтийн өдрөөрх идэвхитэй зах зээлийн үнийг лавлагаа болгосноор тухайн биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжиж болохоор байвал уг дахин үнэлгээний загварыг тэрхүү өдрөөс эхлэн хэрэглэнэ.
84. Хэрэв дахин үнэлгээний үр дүнд биет бус хөрөнгийн дансны үнэ нэмэгдвэл тэрхүү нэмэгдэлтийг дахин үнэлгээний нэмэгдэл дансанд шууд кредитлэнэ. Харин өмнө нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн тухайн нэг хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг буцааж буй хэмжээгээр тэрхүү нэмэгдэлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
85. Хэрэв дахин үнэлгээний үр дүнд биет бус хөрөнгийн дансны үнэ буурвал тэрхүү бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин тухайн нэг хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдэл дансанд тусгагдсан аливаа кредит үлдэгдлийн хэмжээгээр тэрхүү бууралтыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрнө. Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн уг бууралт нь дахин үнэлгээний нэмэгдэл нэрээр цэвэр хөрөнгө/өмчид хуримтлагдан тусгагдсан дүнг бууруулна.
86. Цэвэр хөрөнгө/өмчид тусгагдсан дахин үнэлгээний хуримтлагдсан нэмэгдлийг уг нэмэгдэл хэрэгжсэн үед хуримтлагдсан ашиг, алдагдал дансанд шууд шилжүүлж болно. Ийм нэмэгдэл нь тухайн хөрөнгийг актлах буюу данснаас хасах үед бүхэлдээ хэрэгжиж болох юм. Харин байгууллага нь уг хөрөнгийг ашиглахын хэрээр дахин үнэлгээний нэмэгдлийн зарим хэсгийг шилжүүлж болно; ийм тохиолдолд хэрэгжсэн нэмэгдлийн дүн нь тухайн хөрөнгийн дахин үнэлсэн дансны үнээс тооцсон хорогдуулга ба түүний анхны өртөгт үндэслэн хүлээн зөвшөөрөх байсан хорогдуулгын хоорондох зөрүү байдаг. Дахин үнэлгээний нэмэгдлээс хуримтлагдсан

ашиг, алдагдалд хийгдэх шилжүүлэлтийг ашиг, алдагдлаар дамжуулан тусгахгүй.

## Ашиглалтын хугацаа

87. **Байгууллага нь биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг, хэрэв ашиглалтын хугацаа тодорхой бол түүнийг бүрдүүлж буй хугацааны урт эсвэл бүтээгдэхүүний буюу адилтгах нэгжийн тоог үнэлж үзнэ. Бүх холбогдох хүчин зүйлсийн шинжилгээнд үндэслэн авч үзэхэд уг хөрөнгөөс тухайн байгууллагад цэвэр мөнгөн орлого бий болгох эсвэл үйлчилгээний чадавхи бүрдүүлэхээр хүлээгдэж буй хугацааны хувьд урьдчилан харж болох хязгаар байхгүй тохиолдолд байгууллага нь биет бус хөрөнгийг тодорхой бус ашиглалтын хугацаатай гэж үзнэ.**
88. Биет бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэл нь түүний ашиглалтын хугацаанд үндэслэдэг. Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулна (96-105-р параграфыг үзнэ үү), харин тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулахгүй (106-109-р параграфыг үзнэ үү). Янз бүрийн биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааны тодорхойлолт ба уг ашиглалтын хугацааны тодорхойлолтонд үндэслэсэн тэдгээр хөрөнгүүдийн дараагийн тайлант үеүдийн тайлагналыг энэ Стандартын дагалдах Үлгэрчилсэн жишээнд харуулсан.
89. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлохдоо олон хүчин зүйлсийг харгалзан үздэг. Үүнд:
- (а) Тухайн байгууллага уг хөрөнгийг ашиглах хүлээгдэж буй ашиглалт ба өөр удирдлагын баг тэрхүү хөрөнгийг үр дүнтэйгээр удирдан ашиглаж чадах эсэх;
  - (б) Тухайн хөрөнгөнд хамаарах бүтээгдэхүүний ашиглалтын хэвийн хугацаа ба ижил төсөөтэй байдлаар ашиглаж буй төсөөтэй хөрөнгийн ашиглалтын хугацааны тооцооллын талаархи олон нийтэд нээлттэй мэдээлэл;
  - (в) Техникийн, технологийн, арилжааны болон бусад төрлийн хоцрогдол;
  - (г) Тухайн хөрөнгийн үйл ажиллагаа явуулах салбарын тогтвортой байдал ба уг хөрөнгөөс бий болох бүтээгдэхүүн буюу үйлчилгээний талаархи зах зээлийн эрэлтийн өөрчлөлт;
  - (д) Өрсөлдөгчид буюу боломжит өрсөлдөгчдийн зүгээс явуулахаар хүлээгдэж буй үйл ажиллагаа;
  - (е) Тухайн хөрөнгөөс бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг олж авахад шаардлагатай засвар үйлчилгээний зарлагын түвшин, ийм түвшинд хүрэх уг байгууллагын чадвар боломж ба санаа зорилго;

- (ж) Тухайн хөрөнгөнд хяналт тавих хугацаа, түүнчлэн холбогдох түрээсийн дуусах хугацаа гэх мэт уг хөрөнгийн ашиглалтанд тавигдах хууль эрхзүйн буюу адилтгах хязгаарлалтууд;
- (и) Тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа нь уг байгууллагын бусад хөрөнгүүдийн ашиглалтын хугацаанаас хамааралтай эсэх;
90. “Тодорхой бус” гэсэн нэр томъёо нь “хязгааргүй” гэсэн үг биш юм. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааг тооцоолох үед үнэлж тогтоосон стандарт гүйцэтгэлээр хөрөнгийг хэвийн байлгахад зөвхөн шаардлагатай ирээдүйн засвар үйлчилгээний зардлын түвшин болон ийм түвшинд хүрэх уг байгууллагын чадвар боломж, санаа зорилгыг тусгадаг. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бус гэсэн дүгнэлт нь уг стандарт гүйцэтгэлээр хөрөнгийг хэвийн байлгахад шаардлагатайгаас давсан, ирээдүйн төлөвлөсөн зарлагаас хамаардаггүй байвал зохино.
91. Технологийн хурдацтай өөрчлөлтийн түүхээс харахад, компьютерийн программ хангамж ба бусад олон биет бус хөрөнгө нь технологийн хоцрогдолд өртөмтгий байдаг. Иймээс эдгээр хөрөнгийн ашиглалтын хугацаа ихэвчлэн богино байдаг. Биет бус хөрөнгийг ашигласнаар үйлдвэрлэсэн зүйлийн борлуулалтын үнийн хүлээгдэж буй ирээдүйн бууралт нь тухайн хөрөнгийн технологийн буюу арилжааны хоцрогдлын талаархи хүлээлтийг илэрхийлж болох бөгөөд эргээд энэ нь уг хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралтыг тусган харуулж болох юм.
92. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь маш урт, түүнчлэн тодорхой бус ч байж болно. Ийм тодорхойгүй байдал нь биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг болгоомжилсон сууриар тооцоолох үндэслэл болдог боловч хэт бодитой бус, богино ашиглалтын хугацаа сонгохыг зөвтгөх үндэслэл болохгүй.
93. **Заавал биелүүлэх хэлцлээс (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхээс) үүссэн биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тухайн заавал биелүүлэх хэлцлийн (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхийн) хугацаанаас хэтрэхгүй боловч уг хөрөнгийг байгууллага ашиглахаар хүлээж буй хугацаанаас хамааран дээрх хугацаанаас арай богино байж болох юм. Хэрэв заавал биелүүлэх хэлцлийг (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхийг) дахин сунгаж болох хязгаарлагдмал хугацаатайгаар байгуулдаг бол тухайн байгууллага нь мэдэгдэхүйц зардал гаргахгүйгээр дахин сунгана гэдгийг дэмжих нотолгоо байх зөвхөн тийм тохиолдолд уг биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаанд дахин сунгах хугацааг оруулна.**
- 93A. **Дараах биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тухайн эрхийг олгож буй заавал биелүүлэх хэлцлийн (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхийн) үлдсэн хугацаа байх бөгөөд тэрхүү шинэчилсэн хугацаа үүнд хамаарахгүй:**



- (a) **Нэгдэж буй нэг үйл ажиллагаанаас нэгдэж буй нөгөө үйл ажиллагаанд өмнө олгосон бөгөөд тэрхүү нэгдлийн үр дүн болох байгууллагын хүлээн зөвшөөрсөн лиценз буюу адилтгах эрх; эсвэл**
  - (б) **Улсын секторын нэгдэлд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн, дахин олж эзэмшсэн эрх.**
94. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаанд нөлөөлөх эдийн засгийн, улс төрийн, нийгмийн болон хуулийн хүчин зүйлс байж болох юм. Эдийн засгийн, улс төрийн, нийгмийн хүчин зүйлс нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг уг байгууллага хүлээн авах хугацааг тодорхойлдог. Хуулийн хүчин зүйлс нь эдгээр эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн захиран зарцуулалтанд тухайн байгууллагын хяналт тавих хугацааг хязгаарлаж болох юм. Эдгээр хүчин зүйлсээр тодорхойлогдох хугацааны аль богиноор ашиглалтын хугацааг тогтооно.
95. Бусад зүйлсээс гадна дараах хүчин зүйлс оршин байх нь уг байгууллага мэдэгдэхүйц зардал гаргахгүйгээр тухайн заавал биелүүлэх хэлцлийг (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхийг) сунгах боломжтой гэдгийг илэрхийлнэ:
- (a) Заавал биелүүлэх хэлцлийг (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхийг) дахин сунгана гэсэн нотолгоотой байх, энэ нь өмнөх туршлагад үндэслэсэн байж болно. Хэрэв дахин сунгалт нь гуравдагч талын зөвшөөрлөөс хамаарах бол уг гуравдагч тал зөвшөөрөл өгөх талаархи нотолгоог үүнд хамруулна.
  - (б) Дахин сунгалт хийлгэхэд шаардлагатай аливаа нөхцлүүд хангагдана гэсэн нотолгоотой байх;
  - (в) Дахин сунгалт хийлгэхэд байгууллагаас гарах зардал нь ингэж сунгаснаар тухайн байгууллагад орохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхитай харьцуулахад мэдэгдэхүйц дүнтэй биш байх.

Дахин сунгалт хийлгэх зардал нь ингэж сунгаснаар тухайн байгууллагад орохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхтай харьцуулахад мэдэгдэхүйц дүнтэй бол уг “дахин сунгалт”-ын зардал нь мөн чанарын хувьд тэрхүү дахин сунгах өдрөөр шинэ биет бус хөрөнгө худалдан авах өртгийг илэрхийлэх юм.

## **Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө**

### **Хорогдуулгын хугацаа ба хорогдуулгын арга**

96. **Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна. Хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс өөрөөр хэлбэл, удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил болон нөхцөл байдалд уг**

**хөрөнгийг авчирсан үеэс эхлэн хорогдуулгыг тооцно. Уг хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн өдрөөс эхлэн түүний хорогдуулгыг зогсооно. Ашиглах хорогдуулгын арга нь тухайн байгууллага уг хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зарцуулан ашиглахаар хүлээгдэж буй хэв загварыг тусгасан байвал зохино. Хэрэв тийм хэв загварыг найдвартайгаар тодорхойлж чадахгүй бол шулуун шугамын аргыг хэрэглэнэ. Энэ буюу бусад Стандарт нь хорогдуулгын зардлыг өөр хөрөнгийн дансны үнэд оруулахыг зөвшөөрдөг эсвэл шаарддагаас бусад тохиолдолд тайлант үе бүрийн хорогдуулгын зардлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**

97. Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системтэйгээр хуваарилахын тулд хорогдуулгын янз бүрийн аргуудыг ашиглаж болно. Эдгээр аргад шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга, бүтээгдэхүүний нэгжийн арга хамаарна. Уг хөрөнгөнд агуулагдаж байгаа ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зарцуулахаар хүлээгдэж буй хэв загварт үндэслэн тухайн ашиглах аргыг сонгоно. Тэрхүү ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зарцуулахаар хүлээгдэж буй хэв загвар өөрчлөгдөөгүй л бол тухайн аргаа нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай мөрдөнө.

97А. Биет бус хөрөнгийг ашигладаг, тийм үйл ажиллагаанаас бий болсон орлогод үндэслэсэн хорогдуулгын арга нь тохиромжгүй гэсэн няцааж болох урьдчилсан нөхцөл байдаг. Биет бус хөрөнгийг ашигладаг, тийм үйл ажиллагаанаас бий болсон орлого нь тухайн биет бус хөрөнгөнд агуулагдаж буй эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн зарцуулалттай шууд холбоогүй хүчин зүйлсийг ихэвчлэн тусгасан байдаг. Тухайлбал; бусад орц, боловсруулалт, борлуулалтын үйл ажиллагаа, борлуулалтын тоо хэмжээний болон үнийн өөрчлөлт зэрэг нь орлогод нөлөө үзүүлдэг. Хөрөнгийг ашиглан зарцуулах арга замд ямар нэг нөлөөгүй инфляци нь тухайн орлогын үнийн бүрэлдэхүүн хэсэгт нөлөө үзүүлж болох юм. Зөвхөн дараах цөөн нөхцөл байдалд энэхүү урьдчилсан нөхцлийг няцаах боломжтой байдаг:

- (а) 98В параграфт заасанчлан, биет бус хөрөнгийг орлогын хэмжүүр байдлаар илэрхийлэх тохиолдолд; эсвэл
- (б) Орлого ба тухайн биет бус хөрөнгийн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн зарцуулалт хоорондоо нягт уялдаа холбоотой гэдгийг батлан харуулж чадах тохиолдолд.

97Б. 97-р параграфын дагуу хорогдуулгын тохиромжтой аргыг сонгохдоо, байгууллага нь тухайн биет бус хөрөнгөнд угийн агуулагдаж буй хязгаарлах гол хүчин зүйлийг тодорхойлно. Тухайлбал; биет бус хөрөнгийг ашиглах тухайн байгууллагын эрхийг илэрхийлэх гэрээ нь урьдчилан тодорхойлсон жилийн тоогоор (өөрөөр хэлбэл, хугацаа), үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэгжээр эсвэл олох орлогын нийт тогтмол дүнгээр уг байгууллагын биет бус хөрөнгийн ашиглалтыг тусгайлан тодорхойлсон байж болно. Ийм хязгаарлах гол хүчин зүйлийг тогтоох нь хорогдуулгын тохиромжтой суурийг тодорхойлох эхлэлийн цэг болдог боловч эдийн засгийн үр өгөөж

буюу үйлчилгээний чадавхийн зарцуулалтын хүлээгдэж буй хэв маягийг илүү сайн тусган илэрхийлэх бол өөр суурийг ашиглаж болох юм.

- 97В. Биет бус хөрөнгөнд угийн агуулагдаж буй хязгаарлах гол хүчин зүйл нь орлогын тогтоосон босго шалгуурын биелэлт байх тийм тохиолдолд уг бий болох орлого нь хорогдуулгын тохиромжтой суурь болох юм. Жишээлбэл; төлбөртэй авто зам ажиллуулах эрх нь авто замын хуримтлагдсан хураамжаас бий болох орлогын нийт тогтмол дүнд үндэслэсэн байж болно (жишээ нь; төлбөртэй авто замыг ажиллуулснаас олох хуримтлагдсан орлого нь 100 сая ТН-д хүрэх хүртэл уг төлбөртэй авто замыг ажиллуулахыг гэрээгээр зөвшөөрсөн байж болно). Биет бус хөрөнгийг ашиглах гэрээнд хязгаарлах гол хүчин зүйл болгон орлогыг тодорхойлсон тохиолдолд уг олох орлогын нийт тогтмол дүнг гэрээнд тусгайлан заасан бөгөөд түүнд үндэслэн хорогдуулгыг тодорхойлох бол тэрхүү олох орлого нь биет бус хөрөнгийг хорогдуулах тохиромжтой суурь байж болох юм.
98. Хорогдуулгыг ихэвчлэн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Гэвч зарим тохиолдолд хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь бусад хөрөнгийг үйлдвэрлэн бий болгоход шингэдэг. Энэ тохиолдолд хорогдуулгын зардал нь тэрхүү бусад хөрөнгийн өртгийн нэг хэсгийг бүрдүүлэх бөгөөд түүний дансны үнэд тусган оруулдаг. Жишээлбэл; үйлдвэрлэлийн процессод ашиглагдаж буй биет бус хөрөнгийн хорогдуулгыг бараа материалын дансны үнэд шингээнэ (УСНББОУС 12-ыг үзнэ үү).

#### **Үлдэх өртөг**

99. **Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн үлдэх өртгийг доор дурдснаас бусад тохиолдолд тэг (0) гэж үзнэ:**
- (a) **Тухайн хөрөнгийг түүний ашиглалтын хугацааны эцэст худалдан авах баталгааг гуравдагч тал гаргасан байх; эсвэл**
  - (б) **Тухайн хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээл оршин байх ба;**
    - (i) **Уг зах зээлийн үнийг лавлагаа болгосноор үлдэх өртгийг тодорхойлох боломжтой байх; ба**
    - (ii) **Уг хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст ийм зах зээл оршин байх нь нилээд магадлалтай байх.**
100. Тодорхой ашиглалтын хугацаатай хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний үлдэх өртгийг хассаны дараа тодорхойлно. Тэгээс өөр дүн бүхий үлдэх өртөг нь тухайн биет бус хөрөнгийг байгууллага түүний эдийн засгийн үр ашигтай хугацааны эцэс болохоос өмнө данснаас хасахаар төлөвлөж байна гэсэн утгатай юм.
101. Хөрөнгийг ашиглах нөхцөлтэй ижил нөхцөлд ажиллаж байсан бөгөөд ашиглалтын хугацааныхаа эцэст хүрсэн ижил төсөөтэй хөрөнгийн борлуулалтын хувьд уг тооцооллын өдрөөр нийтлэг байгаа үнүүдийг ашиглан тооцсон тухайн хөрөнгийн данснаас хасалтаас нөхөгдөх дүнд

үндэслэн энэхүү хөрөнгийн үлдэх өртгийг тооцоолно. Үлдэх өртгийг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзнэ. Тухайн хөрөнгийн үлдэх өртгийн өөрчлөлтийг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт байдлаар тайлагнана.

102. Биет бус хөрөнгийн үлдэх өртөг нь тухайн хөрөнгийн дансны үнэтэй тэнцүү эсвэл түүнээс их болон өсөж болох юм. Хэрэв ийм тохиолдол гарвал, үлдэх өртөг дараа нь буурч, тухайн хөрөнгийн дансны үнээс бага болох хүртэл, түүнчлэн ингэж бага болохгүй байх үед уг хөрөнгийн хорогдуулгын зардал нь тэг байна.

### **Хорогдуулгын хугацаа ба хорогдуулгын аргыг хянах**

103. **Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулгын хугацаа ба хорогдуулгын аргыг наад зах нь, тайлангийн өдөр бүрээр хянаж үзнэ. Хэрэв уг хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаа нь өмнөх тооцооллоос өөр байвал хорогдуулгын хугацааг зохих ёсоор өөрчилнө. Хэрэв тухайн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зарцуулахаар хүлээгдэж буй хэв загвар өөрчлөгдсөн бол тэрхүү өөрчлөгдсөн хэв загварыг тусгахын тулд хорогдуулгын аргыг өөрчилнө. Ийм өөрчлөлтийг УСНББОУС 3-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт байдлаар тайлагнана.**
104. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааны тооцоолол тохиромжтой бус гэдэг нь түүний ашиглалтын явцад тодорхой болж болох юм. Жишээлбэл; үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөх нь тухайн хорогдуулгын хугацааг өөрчлөх шаардлагатай гэдгийг илэрхийлж болох юм.
105. Биет бус хөрөнгөөс тухайн байгууллагад орохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн хэв загвар нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж болно. Жишээлбэл; хорогдуулга тооцох үлдэгдлийг бууруулах арга нь шулуун шугамын аргаас илүү тохиромжтой гэдэг нь тодорхой болж болох юм. Өөр нэг жишээ дурдвал; лицензээр илэрхийлэгдэх эрхийн ашиглалт нь тухайн байгууллагын стратегийн төлөвлөгөөний бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн ажиллагаанаас хамааран хойшлогдож болно. Энэ тохиолдолд уг хөрөнгөөс орох эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг дараагийн тайлангийн үеүд хүртэл хүлээн авахгүй байж болох юм.

### **Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө**

106. **Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулахгүй.**
107. УСНББОУС 21 ба УСНББОУС 26-гийн дагуу, байгууллага нь тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө болон хараахан ашиглах боломжгүй биет бус хөрөнгийн нөхөгдөх дүн эсвэл нөхөгдөх үйлчилгээний

дүнгийн аль тохиромжтойг түүний дансны үнэтэй харьцуулах замаар үнэ цэнийн бууралтыг дараах байдлаар сорьж шалгах шаардлагатай байдаг:

- (а) Жил бүр; ба
- (б) Биет бус хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох шинж тэмдэг байгаа тохиолдол бүрд.

#### **Ашиглалтын хугацааны үнэлгээг хянах**

- 108. **Хорогдол тооцдоггүй биет бус хөрөнгийн хувьд түүний тодорхой бус ашиглалтын хугацаатай гэсэн үнэлгээг дэмжих үйл явдал ба нөхцөл байдал хэвээр байгаа эсэхийг тодорхойлохын тулд ийм биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тайлант үе бүр хянаж үзнэ. Хэрэв ийм үйл явдал ба нөхцөл байдал үгүй болсон бол ашиглалтын хугацааг тодорхой бусаас тодорхой болгох уг өөрчлөлтийг УСНББОУС 3-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж тайлагнана.**
- 109. УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхой бус биш, харин тодорхой болгон дахин үнэлж буй явдал нь уг хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох шинж тэмдэг юм. Иймээс байгууллага нь УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу тодорхойлсон уг хөрөнгийн нөхөгдөх дүн буюу нөхөгдөх үйлчилгээний дүнг түүний дансны үнэтэй харьцуулах замаар үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах бөгөөд нөхөгдөх үйлчилгээний дүн эсвэл нөхөгдөх дүнгийн аль тохиромжтой дүнгээс давсан дансны үнийн аливаа хэтрэлтийг үнэ цэнийн бууралтын гарз гэж хүлээн зөвшөөрнө.

#### **Дансны үнийн нөхөгдөх байдал - Үнэ цэнийн бууралтын гарз**

- 110. Биет бус хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтойг мөрдөнө. Эдгээр Стандартууд нь байгууллага тухайн хөрөнгийн дансны үнийг хэзээ, хэрхэн дахин шалгах, түүнчлэн уг хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүн эсвэл нөхөгдөх дүнгийн аль тохиромжтойг хэрхэн тодорхойлох ба үнэ цэнийн бууралтын гарзыг хэзээ хүлээн зөвшөөрөх эсвэл буцаах эсэхийг тайлбарласан байдаг.

#### **Ашиглалтыг зогсоолт ба данснаас хасалт**

- 111. **Биет бус хөрөнгийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө:**
  - (а) **Данснаас хасахад (үүн дотроо, арилжааны бус ажил гүйлгээгээр данснаас хасах); эсвэл**
  - (б) **Хөрөнгийн ашиглалт болон данснаас хасалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи олохооргүй болсон үед.**

112. **Биет бус хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз буюу гарзыг хэрэв байгаа бол данснаас хасалтын цэвэр орлого ба тухайн хөрөнгийн дансны үнэ хоорондох зөрүүгээр тодорхойлно. Олз, гарзыг тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн үед (УСНББОУС 13 нь борлуулалт ба буцаан түрээслэлтийн хувьд өөрөөр зааснаас бусад тохиолдолд) ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**
113. Биет бус хөрөнгийн данснаас хасалтыг янз бүрийн арга замаар (жишээлбэл; борлуулах, санхүүгийн түрээсээр өгөх, арилжааны бус ажил гүйлгээгээр шилжүүлэх) гүйцэтгэж болох юм. Ийм хөрөнгийн данснаас хасалтын өдрийг тодорхойлохдоо, байгууллага нь бараа борлуулалтаас үүсэх орлогын хүлээн зөвшөөрөлтийн хувьд УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-д заасан шалгуурыг мөрдөнө. Борлуулалт ба буцаан түрээслэлтээр хийгдсэн данснаас хасалтын хувьд УСНББОУС 13-ыг мөрдөнө.
114. Хэрэв 28-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу, байгууллага нь биет бус хөрөнгийн тодорхой хэсгийн хувьд хийгдсэн орлуулалтын өртгийг уг биет бус хөрөнгийн дансны үнэд оруулан хүлээн зөвшөөрдөг бол тэрхүү орлуулагдан хасагдаж буй хэсгийн дансны үнийг үл хүлээн зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь орлуулагдан хасагдаж буй хэсгийн дансны үнийг тодорхойлох практик боломжгүй байвал тэрхүү орлуулагдан хасагдаж буй хэсгийг худалдан авах эсвэл дотооддоо бий болгох тухайн хугацааны өртгийн үзүүлэлт гэдэг утгаар уг орлуулан нэмэгдэж буй өртгийг ашиглаж болно.
- 114А. Дараах тохиолдолд тухайн эрхийг дараагийн тайлант үед гуравдагч талд буцаан гаргасан (борлуулсан) бол уг буцаан гаргалтын олз, гарзыг тодорхойлохдоо хэрэв байгаа бол, тэрхүү эрхийн холбогдох дансны үнийг ашиглана.
- (а) Нэгдэж буй нэг үйл ажиллагаанаас нэгдэж буй нөгөө үйл ажиллагаанд өмнө олгосон бөгөөд тэрхүү нэгдлийн үр дүн болох байгууллагын хүлээн зөвшөөрсөн лиценз буюу адилтгах эрх; эсвэл
  - (б) Улсын секторын нэгдэлд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн, дахин олж эзэмшсэн эрх.
115. Биет бус хөрөнгийн данснаас хасалтаар авах төлбөрийг түүний бодит үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрнө. Хэрэв биет бус хөрөнгийн төлбөрийг хойшлуулвал уг хүлээн авах төлбөрийг түүний мөнгөн үнэтэй адилтгах дүнгээр анх хүлээн зөвшөөрнө. Төлбөрийн нэрлэсэн дүн ба мөнгөн үнэтэй адилтгах дүн хоорондох зөрүүг тухайн авлагын үр ашигт өгөөжийг тусгах хүүний орлого байдлаар УСНББОУС 9-ийн дагуу хүлээн зөвшөөрнө.
116. Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг ашиглахгүй байлаа ч гэсэн түүнийг бүрэн элэгдүүлснээс бусад тохиолдолд хорогдуулгыг зогсоохгүй.

## Тодруулга

### Ерөнхий зүйл

117. Байгууллага нь дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө ба бусад биет бус хөрөнгө гэдгээр ангилж, биет бус хөрөнгийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:
- (a) Ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэх, хэрэв тодорхой бол ашиглалтын хугацаа буюу ашигласан хорогдуулгын хувь хэмжээ;
  - (б) Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хувьд ашигласан хорогдуулгын аргууд;
  - (в) Тайлант үеийн эхэн ба эцэс дэх нийт дансны үнэ болон аливаа хуримтлагдсан хорогдуулга (хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзтай нэгтгэн нийлүүлсэн);
  - (г) Биет бус хөрөнгийн аливаа хорогдуулгыг тусгасан, санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйл;
  - (д) Доорх зүйлсийг харуулсан, тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнийн тохируулга:
    - (i) Нэмэгдэлт, үүнд дотоодын хөгжүүлэлтээс бий болсон, тусад нь худалдаж авсан, нэгдлээр олж авсан гэдгээр тусдаа харуулах;
    - (ii) Данснаас хасалт;
    - (iii) 74, 84, 85-р параграфын дагуу дахин үнэлгээний үр дүнд тухайн тайлант үеийн туршид нэмэгдсэн буюу буурсан дүн (хэрэв байгаа бол);
    - (iv) УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн дагуу тухайн тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз (хэрэв байгаа бол);
    - (v) УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн дагуу тухайн тайлант үед ашиг, алдагдалд буцаан тусгасан үнэ цэнийн бууралтын гарз (хэрэв байгаа бол);
    - (vi) Тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн аливаа хорогдуулга;
    - (vii) Санхүүгийн тайланг толилуулгын валютад хөрвүүлснээс, мөн гадаад үйл ажиллагааг тухайн тайлагнагч байгууллагын толилуулгын валютад хөрвүүлснээс үүссэн ханшийн цэвэр зөрүү; ба
    - (viii) Тухайн тайлант үеийн туршид дансны үнэд орсон бусад өөрчлөлтүүд.

118. Биет бус хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдлын хувьд ижил төсөөтэй шинж төрөл ба хэрэглээ бүхий хөрөнгүүдийн бүлэг юм. Ийм тусдаа ангиудын жишээг доор харуулав:

- (а) Брэнд нэр;
- (б) Сонин хэвлэлийн нүүрэн хэсэгт бичигдэх эрх ба хэвлэлийн эрх;
- (в) Компьютерийн программ хангамж;
- (г) Лиценз;
- (д) Зохиогчийн эрх, патент ба аж үйлдвэрлэлийн бусад өмчийн эрх, үйлчилгээний болон үйл ажиллагааны эрхүүд;
- (е) Жор, томьёолол, загвар, дизайн, эх загвар; ба
- (ж) Хөгжүүлэлт хийгдэж буй биет бус хөрөнгөнүүд.

Хэрэв үр дүн нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн хувьд илүү хамааралтай мэдээллийг бий болгохоор байвал дээр дурдсан ангиудыг арай жижиг (том) ангиудад салган (нэгтгэн) ангилна.

119. Энэ Стандартын 117(д)(iii)-(v) параграфтаар шаардсан мэдээллээс гадна байгууллага нь үнэ цэнэ буурсан биет бус хөрөнгийн талаархи мэдээллийг УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн дагуу тодруулна.

120. УСНББОУС 3 нь тухайн тайлант үед материаллаг үр нөлөөтэй эсвэл дараагийн тайлант үеүдэд материаллаг үр нөлөөтэй байхаар хүлээгдэж буй нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн шинж төрөл ба дүнг тодруулахыг байгууллагаас шаарддаг. Дараах зүйлсийн талаархи тооцооллын өөрчлөлтийн улмаас ийм тодруулгыг хийж болно:

- (а) Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааны үнэлгээ;
- (б) Хорогдуулгын арга; эсвэл
- (в) Үлдэх өртөг.

121. **Байгууллага нь мөн дараах зүйлсийг тодруулна:**

- (а) **Тодорхой бус ашиглалтын хугацаатай гэж үнэлсэн биет бус хөрөнгийн хувьд уг хөрөнгийн дансны үнэ ба тодорхой бус ашиглалтын хугацаатай гэсэн үнэлгээг дэмжих шалтгаан үндэслэл. Эдгээр шалтгааныг харгалзан үзсэнээр уг байгууллага нь тухайн хөрөнгийг тодорхой бус ашиглалтын хугацаатай гэж тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн хүчин зүйлсийг тодорхойлно.**
- (б) **Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн хувьд материаллаг байх аливаа бие даасан биет бус хөрөнгийн тайлбар тодорхойлолт, түүний дансны үнэ болон үлдсэн хорогдуулгын хугацаа;**



- (в) **Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн ба анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрсөн биет бус хөрөнгийн хувьд (42-43-р параграфыг үзнэ үү):**
  - (i) **Тэдгээр хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнэ;**
  - (ii) **Тэдгээрийн дансны үнэ; ба**
  - (iii) **Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа тэдгээрийг өртгийн загвараар эсвэл дахин үнэлгээний загвараар хэмжсэн эсэх;**
- (г) **Эрх хязгаарлагдсан биет бус хөрөнгө оршин байгаа эсэх ба түүний дансны үнэ, түүнчлэн өр төлбөрийн баталгаа болгон барьцаалсан биет бус хөрөнгийн дансны үнэ;**
- (д) **Биет бус хөрөнгийг худалдан авах гэрээт баталгааны дүн.**

122. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхой бус гэж тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн хүчин зүйлсийг тодорхойлохдоо байгууллага нь 89-р параграфт жагсаан харуулсан хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

**Хүлээн зөвшөөрөлтийн дараа дахин үнэлгээний загвар ашиглан хэмжсэн биет бус хөрөнгө**

123. **Хэрэв биет бус хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр тайлагнасан бол байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**

- (а) **Биет бус хөрөнгийн анги тус бүрээр:**
  - (i) **Дахин үнэлгээний хүчин төгөлдөр болох хугацаа;**
  - (ii) **Дахин үнэлсэн биет бус хөрөнгийн дансны үнэ; ба**
  - (iii) **Хэрэв дахин үнэлсэн биет бус хөрөнгийн ангийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, 73-р параграфт заасан өртгийн загвар ашиглан хэмжсэн бол хүлээн зөвшөөрөх байсан дансны үнэ;**
- (б) **Тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх биет бус хөрөнгөтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдлийн дүн, түүнчлэн уг тайлант үед гарсан өөрчлөлт ба эздэд хуваарилах үлдэгдэлд тавигдах аливаа хязгаарлалтыг заан илэрхийлэх.**
- (в) **Тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо хэрэглэсэн аргууд болон гол таамаглалууд.**

124. Дахин үнэлсэн хөрөнгийн ангиудыг тодруулгын зорилгоор илүү том ангид нэгтгэн нийлүүлэх шаардлагатай байж болох юм. Гэвч энэ нь өртгийн ба дахин үнэлгээний загварын аль алины дагуу хэмжсэн дүнгүүд бүхий биет бус хөрөнгийн ангиудыг нэгтгэн нийлүүлэхэд хүргэхээр байвал тийм ангиудыг нэгтгэхгүй.

### **Судалгаа ба хөгжүүлэлтийн зардал**

125. **Байгууллага нь тухайн тайлант үеийн туршид зардал гэж хүлээн зөвшөөрсөн судалгаа ба хөгжүүлэлтийн зарлагын нэгдсэн дүнг тодруулна.**
126. Судалгаа ба хөгжүүлэлтийн зардал нь судалгаа буюу хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд шууд хамааруулж болох бүх зарлагаас бүрдэнэ. (125-р параграфт заасан тодруулгын шаардлагын зорилгын хувьд хамааруулан оруулах зарлагын төрлийн талаархи заавар удирдамжийг 64, 65-р параграфтаас үзнэ үү).

### **Бусад мэдээлэл**

127. Байгууллага нь дараах мэдээллийг тодруулахыг дэмжих боловч заавал шаардахгүй:
- (а) Бүрэн хорогдуулсан боловч одоо ч ашигласаар байгаа биет бус хөрөнгийн тайлбар тодорхойлолт; болон
  - (б) Байгууллага нь хяналтандаа авсан боловч энэ Стандартад заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаагүй учраас хүлээн зөвшөөрөөгүй байгаа мэдэгдэхүйц дүн бүхий биет бус хөрөнгийн талаархи товч тайлбар тодорхойлолт.

### **Шилжилтийн нөхцөл**

128. **Биет бус хөрөнгийг өмнө нь хүлээн зөвшөөрсөн байгууллага нь УСНББОУС 3-ын дагуу энэ Стандартыг буцаах горимоор мөрдөнө.**
129. [Хассан]
130. [Хассан]
131. [Хассан]
- 131А. 2015 оны 01 дүгээр сард гаргасан, *УСНББОУС 2014-ийн Сайжруулалтууд*-ын үр дүнд 79-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг анх мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх жилийн тайлант үед болон түүний яг өмнөх жилийн тайлант үед хүлээн зөвшөөрсөн бүх үнэлгээнд энэхүү нэмэлт өөрчлөлтийг даган мөрдөнө.

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

132. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2011 оны 4 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2011 оны 4 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 21 болон УСНББОУС 26-г мөрдөнө.**

- 132А. 2011 оны 10 дугаар сард гаргасан УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ээр 6-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2014 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 32, УСНББОУС 5-ын 6 ба 42А параграфын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 13-ын 25-27, 85Б параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 17-гийн 5, 7, 107В параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 29-ийн 2, 125А параграфын нэмэлт өөрчлөлтийг тус тус даган мөрдөнө.
- 132Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2014-ийн Сайжруулалтууд*-ын үр дүнд 79, 91, 97-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 97А, 97Б, 97В, 131А параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2015 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд гүйцээх горимоор мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 132В. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 129, 130, 131, 133-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 132Г. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* ба УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-ийн үр дүнд 6(г) параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 35 ба УСНББОУС 37-г мөрдсөн үеэс уг нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөнө.
- 132Д. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар 3, 96, 116, 117-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 132Е. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 4, 5-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 132Ж. *Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* (УСНББОУС 21 ба УСНББОУС 26-гийн нэмэлт өөрчлөлтүүд)-ын үр дүнд 110-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 132И. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 6, 35, 64-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.
- 132К. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 3, 6, 18, 24, 40, 41, 66, 67, 117-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 18А, 26А, 39А-39Д, 93А, 114А параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд гүйцээх горимоор мөрдөнө. Иймээс урьд өмнөх улсын секторын нэгдлээр биет бус хөрөнгө болон гүүдвилийн хувьд хүлээн зөвшөөрсөн дүнг залруулахгүй. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
133. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт* (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

**Хавсралт А****Мөрдөх заавар удирдамж**

*Энэ Хавсралт нь УСНББОУС 31-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

**Вэб сайтын өртөг**

- МЗУ1. Байгууллага нь дотоодын буюу гаднын хандан нэвтрэлтэд зориулан өөрийн вэб сайтыг хөгжүүлэх ба ажиллуулахад дотоод зарлага гаргаж болох юм. Гаднын хандан нэвтрэлтэд зориулан зохиомжилсон вэб сайтыг янз бүрийн зорилгоор ашиглаж болно. Үүнд: мэдээллийг түгээх, үйлчилгээний танилцуулга хийх, хууль тогтоомжийн төсөл дээр санал авах хүсэлт гаргах, тухайн байгууллагын өөрийн үйлчилгээ болон бүтээгдэхүүнийг сурталчлах ба урамшуулах, цахим үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээ ба бүтээгдэхүүнийг борлуулах гэх мэт. Дотоод хандан нэвтрэлтэд зориулан зохиомжилсон вэб сайтыг тухайн байгууллагын бодлого болон үйлчилгээний хэрэглэгчдийн дэлгэрэнгүй мэдээллийг хадгалах, холбогдох мэдээллийг эрж хайхын тулд ашиглаж болно.
- МЗУ2. Вэб сайтын хөгжүүлэлтийн үе шатуудыг дараах байдлаар тодорхойлж болно:
- (а) Төлөвлөлт – үүнд: хэрэгжих боломжит байдлын судалгаа хийх, зорилго болон техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлох, хувилбаруудыг үнэлэх, хамгийн тохиромжтойг сонгох ажиллагаа хамаарна;
  - (б) Хэрэглээний программууд ба Дэд бүтцийн хөгжүүлэлт – үүнд: домэйн нэр авах, техник хэрэгсэл болон үйлдлийн программ хангамжийг худалдан авах ба хөгжүүлэх, боловсруулсан хэрэглээний программыг суулгах, ачаалал даах чадварыг сорьж шалгах ажиллагаа хамаарна;
  - (в) График дизайны хөгжүүлэлт – үүнд: вэб сайтын харагдах байдлыг зохиомжлох ажиллагаа хамаарна;
  - (г) Контентын хөгжүүлэлт – үүнд: текстэн буюу графикан мэдээллийг үүсгэх, худалдан авах, бэлтгэх ба вэб сайтын хөгжүүлэлтийг дуусгахаас өмнө тухайн вэб сайтад ачаалан байршуулах ажиллагаа хамаарна. Энэхүү мэдээллийг уг вэб сайтанд нэгтгэж (эсвэл вэб сайтаас хандаж болох) мэдээний тусдаа баазад хадгалж эсвэл вэб хуудсанд шууд кодчилон оруулж болно.
- МЗУ3. Вэб сайтын хөгжүүлэлт дуусмагц Үйл ажиллагааны үе шат эхэлнэ. Энэхүү үе шатны явцад байгууллага нь хэрэглээний программ, дэд бүтэц, график дизайн, вэб сайтын контентыг хэвийн хадгалан ажилуулах ба сайжруулах ажлыг хийдэг.
- МЗУ4. Байгууллага нь дотоодын буюу гаднын хандан нэвтрэлтэд зориулан өөрийн вэб сайтыг хөгжүүлэх ба ажиллуулахад гардаг дотоод зарлагыг тайлагнах үед дараах асуудлуудыг харгалзан үзнэ:

- (а) Уг вэб сайт нь энэ Стандартын шаардлагуудад захирагдах дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө эсэх; ба
  - (б) Ийм зарлагыг бүртгэх нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой арга хандлага.
- МЗУ5. Энэхүү Мөрдөх заавар удирдамжийг вэб сайтны техник хэрэгслийг (жишээлбэл; вэб сайтын сервер, үе шатлах сервер, үйлдвэрлэлийн сервер, интернет холболтыг) худалдан авах, хөгжүүлэх, ажиллуулахтай холбоотой зарлагад мөрдөхгүй. Ийм зарлагыг УСНББОУС 17-гийн дагуу тайлагнана. Түүнчлэн, байгууллага нь түүний вэб сайтыг байршуулж буй Интернет үйлчилгээ үзүүлэгчийн хувьд зарлага гаргасан тохиолдолд тэрхүү зарлагыг тухайн үйлчилгээг хүлээн авсан үед зардал гэж хүлээн зөвшөөрнө.
- МЗУ6. Байгууллага нь хэвийн үйл ажиллагааны явцад борлуулах зорилгоор эзэмшиж буй биет бус хөрөнгөнд (УСНББОУС 11 ба УСНББОУС 12-ыг үзнэ үү) эсвэл УСНББОУС 13-ын цар хүрээнд хамаарах түрээсийн хувьд УСНББОУС 31-ийг мөрдөхгүй. Иймээс өөр байгууллагад борлуулах зорилго бүхий вэб сайтыг (буюу вэб сайтын программ хангамжийг) хөгжүүлэх болон ажиллуулах зарлагад энэхүү Мөрдөх заавар удирдамжийг мөрдөхгүй. Вэб сайтыг үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслэж байгаа тохиолдолд түрээслүүлэгч нь энэхүү Мөрдөх заавар удирдамжийг мөрдөнө. Вэб сайтыг санхүүгийн түрээсийн дагуу түрээслэж байгаа тохиолдолд түрээслэгч нь уг түрээслэсэн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа энэхүү Мөрдөх заавар удирдамжийг мөрдөнө.
- МЗУ7. Хөгжүүлэн бий болгосон бөгөөд дотоодын буюу гаднын хандан нэвтрэлтэд зориулсан уг байгууллагын вэб сайт нь энэ Стандартын шаардлагуудад захирагдах дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө юм.
- МЗУ8. Дотоод хөгжүүлэлтээр бий болсон вэб сайт нь энэ Стандартын 28-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн болон анхны хэмжилтийн ерөнхий шаардлагуудыг хангахаас гадна байгууллага нь Стандартын 55-р параграфын шаардлагуудыг биелүүлж байвал, зөвхөн тийм тохиолдолд уг вэб сайтыг биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Тухайлбал; вэб сайт нь орлого олох, үүн дотроо төрийн албан хаагч нь ажлын байран дээр биетээр үйлчилгээ үзүүлэхийн оронд вэб сайтыг ашигласнаар захиалга өгөх нөхцөл бүрдүүлэх буюу үйлчилгээ үзүүлэх замаар шууд орлого бий болгох чадвар боломжтой тохиолдолд энэ Стандартын 55(г) параграфт заасанчлан, түүний вэб сайт нь ирээдүйн магадлалт эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг хэрхэн бий болгохыг батлан харуулах шаардлагыг тухайн байгууллага нь ханган биелүүлэх боломжтой байж болох юм. Зөвхөн өөрийн үйлчилгээ буюу бүтээгдэхүүнийг сурталчлах болон дэмжин урамшуулахын тулд үндсэндээ хөгжүүлэн боловсруулсан вэб сайт нь ирээдүйн магадлалт эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг хэрхэн бий болгохыг уг байгууллага батлан харуулж чадахгүй ба иймээс тэрхүү вэб

сайтыг хөгжүүлэхэд гаргасан бүх зарлагыг тэдгээрийн гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.

- МЗУ9. Байгууллагын өөрийн вэб сайтыг хөгжүүлэх ба ажиллуулахад гаргасан аливаа дотоод зарлагыг энэ Стандартын дагуу тайлагнана. Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой арга хандлагыг тодорхойлохын тулд зарлага гаргаж буй үйл ажиллагаа нэг бүрийн шинж төрөл (жишээлбэл; ажилтны сургалт, вэб сайтын засвар үйлчилгээ) ба вэб сайтын хөгжүүлэлтийн буюу хөгжүүлэлтийн дараах үе шатыг үнэлж шалгана (Үлгэрчилсэн жишээний эцэст харуулсан хүснэгтэнд нэмэлт заавар удирдамжийг тусгасан). Жишээлбэл;
- (а) Төлөвлөлтийн үе шат нь энэ Стандартын 52-54-р параграфт заасан, судалгааны үе шаттай мөн чанарын хувьд ижил төсөөтэй байдаг. Энэ үе шатанд гарсан зарлагыг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө;
  - (б) Хэрэглээний программ болон дэд бүтцийн хөгжүүлэлтийн үе шат, График дизайны үе шат болон тухайн байгууллагын өөрийн үйлчилгээ буюу бүтээгдэхүүнийг сурталчлах, дэмжин урамшуулахаас өөр бусад зорилгоор хөгжүүлэн боловсруулсан тохиолдолд Контентын хөгжүүлэлтийн үе шат нь энэ Стандартын 55-62-р параграфт заасан, хөгжүүлэлтийн үе шаттай мөн чанарын хувьд ижил төсөөтэй байдаг. Эдгээр үе шатанд гарсан зарлага нь удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажилуулах боломжтой болгохын тулд вэб сайтыг үүсгэх, бий болгох, бэлтгэх ажиллагаатай шууд холбоотой бөгөөд зайлшгүй шаардлагатай тохиолдолд МЗУ8-р параграфын дагуу биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн вэб сайтын өртөгт эдгээр зарлагыг оруулна. Жишээлбэл; вэб сайтад тусгайлан зориулагдсан контентыг (байгууллагын өөрийн үйлчилгээ болон бүтээгдэхүүнийг сурталчлах, дэмжин урамшуулахаас бусад контентыг) худалдан авах буюу үүсгэн бий болгох зарлага болон уг вэб сайтын контентыг ашиглах боломж бүрдүүлэх зарлагыг (жишээ нь; хувилан олшруулах зөвшөөрлийг олж авах төлбөр) энэхүү нөхцөл хангагдаж байх тохиолдолд хөгжүүлэлтийн өртөгт оруулан тусгана. Гэвч энэ Стандартын 83-р параграфын дагуу, өмнөх санхүүгийн тайланд зардал гэж анх хүлээн зөвшөөрсөн биет бус зүйлсийн зарлагыг хожим нь биет бус хөрөнгийн өртгийн нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрөхгүй (жишээ нь; зохиогчийн эрхийн өртгийг бүрэн хорогдуулсан ба контентыг хожим нь вэб сайтанд байршуулсан бол);
  - (в) Байгууллагын өөрийн үйлчилгээ болон бүтээгдэхүүнийг (жишээлбэл; бүтээгдэхүүний цахим фото зураг) сурталчлах буюу дэмжин урамшуулахын тулд уг контентыг хөгжүүлэн боловсруулсан тохиолдолд Контентын хөгжүүлэлтийн үе шатанд гаргасан зарлагыг энэ Стандартын 67(в) параграфын дагуу гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; байгууллагын өөрийн бүтээгдэхүүний цахим фото зургийг авах ба зургийн чанарыг сайжруулах мэргэжлийн үйлчилгээний зарлагыг тайлагнах

## БИЕТ БУС ХӨРӨНГӨ

тохиолдолд уг цахим зургийг вэб сайтанд байршуулсан үед биш, харин тухайн процессын явцад тэрхүү мэргэжлийн үйлчилгээг хүлээн авсан үед холбогдох зарлагыг зардал гэж хүлээн зөвшөөрнө; ба

- (г) Вэб сайтын хөгжүүлэлт дуусмагц Үйл ажиллагааны үе шат эхэлнэ. Энэ үе шатанд гарсан зарлагыг Стандартын 28-р параграфт заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахаас бусад тохиолдолд гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.

МЗУ10. Энэ Мөрдөх заавар удирдамжийн МЗУ8-р параграфын дагуу биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн вэб сайтыг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, Стандартын 71-86-р параграфын шаардлагуудыг мөрдсөнөөр хэмжинэ. Вэб сайтын ашиглалтын хугацааны хамгийн сайн тооцоолол нь 91-р параграфт заасанчлан, богино хугацаа байвал зохино.

МЗУ11. МЗУ1-МЗУ10-р параграфт дурдсан, заавар удирдамжийг программ хангамжийн хөгжүүлэлтийн өртөгт тусгайлан мөрдөхгүй. Гэвч байгууллага нь эдгээр параграфт тусгасан зарчмуудыг мөрдөж болох юм.



## Хавсралт В

### Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 31-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Оршил

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. Улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгаан байхаас бусад тохиолдолд СТОУС-тай нийцүүлсэн, аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-ын шаардлага, бүтэц, текстийг тэр хэвээр хадгална. СТОУС-ын шаардлага буюу нэр томъёо нь улсын секторт тохиромжгүй эсвэл улсын секторын хувьд зарим тодорхой шаардлагуудыг үлгэрчлэн харуулахын тулд нэмэлт тайлбар буюу жишээ оруулах шаардлагатай тохиолдолд адилтгах СТОУС-аас гаждаг. УСНББОУС-ууд ба тэдгээртэй адилтгах СТОУС-уудын хоорондох ялгаатай талуудыг УСНББОУС нэг бүрд тусган оруулсан *СТОУС-тай Харьцуулалт*-д тодорхойлсон. НББОУС 38-тай Харьцуулалт нь НББОУС 38-ын 2008 оны 12 дугаар сарын 31-ний хувилбарт үндэслэсэн.

### Цар хүрээ

- ДҮ3. Зөвлөл нь хууль тогтоомж, дүрэм буюу адилтгах арга хэрэгслээр олгосон бүрэн эрх ба эрхийг энэ Стандартын цар хүрээнд оруулах эсэхийг харгалзан үзсэн. Зөвлөл нь энэ сэдвийн талаархи өөрийн үзэл бодлыг гаргаагүй ба иймээс эдгээр бүрэн эрх ба эрхийг энэ Стандартын цар хүрээнээс хассан. Зөвлөл нь Онолын Үзэл Баримтлалыг одоо боловсруулж байгаа бөгөөд хууль тогтоомж, дүрэм буюу адилтгах арга хэрэгслээр олгосон бүрэн эрх ба эрхэд энэ Стандартын мөрдөгдөх боломжит байдлыг хэрэв шаардагатай бол дахин харгалзан авч үзнэ.
- ДҮ4. НББОУС 38 нь бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн гүүдвил ба биет бус хөрөнгийн талаархи шаардлагууд болон заавар удирдамжуудыг агуулсан байдаг. Бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн гүүдвил болон биет бус хөрөнгийг энэ Стандартын цар хүрээнд хамруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУС3 нь УСНББОУС 31-ийг гаргах үедээ харгалзан үзсэн. УСНББОУС3 нь бизнесийн нэгдлийг зохицуулах УСНББОУС-ыг хараахан гаргаагүй байгаа бөгөөд улсын секторын байгууллагуудын нэгдэл хийгдсэн үед улсын секторын олон тооны тусгай асуудлууд үүсэх магадлалтай гэж үзсэн. Бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн гүүдвил болон биет бус хөрөнгийг одоогоор энэ Стандартын цар хүрээнд хамруулан оруулах хэрэггүй гэж УСНББОУС3 дүгнэсэн. УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-нд заасан шатлалын дагуу хэрэглэгчид нь

бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн гүүдвил болон биет бус хөрөнгийг тайлагнах олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын шаардлагуудыг лавлагаа болгон харгалзана.

- ДҮ4А. УСНББОУСЗ дараа нь УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийг гаргасан. УСНББОУС 40 нь улсын секторын нэгдлийн тайлагнал, үүн дотроо биет бус хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг тусгайлан тодорхойлдог. Улсын секторын нэгдлийн нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрсөн биет бус хөрөнгийн дараагийн тайлант үеийн хэмжилт ба тодруулгыг УСНББОУС 40-д заагаагүй байдаг. Иймээс улсын секторын нэгдлээр хүлээн зөвшөөрсөн гүүдвил болон биет бус хөрөнгийг энэ Стандартын цар хүрээнд оруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь дахин авч үзсэн. УСНББОУСЗ нь УСНББОУС 40-ийг гаргаж, энэ Стандартад зохих өөрчлөлтийг оруулсаны үр дүнд эдгээр хөрөнгийг энэ Стандартын цар хүрээнд хамруулан оруулах хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ5. Солилцооны ажил гүйлгээ нь худалдаа арилжааны мөн чанаргүй байх үед хөрөнгийн солилцоонд тавигдах шаардлагуудыг НББОУС 38-д тусгасан байдаг. УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамж шаардлагатай эсэхийг харгалзан үзсэн ба уг асуудлыг УСНББОУС 23-т авч үзсэн учраас ийм заавар удирдамж шаардлагагүй гэж дүгнэсэн.
- ДҮ6. НББОУСЗ нь вэб сайтын өртгийн тайлагналыг зохицуулах НББОУС 38-ын Тайлбарыг гаргасан. ТБХ 32-т тусгагдсан заавар удирдамж нь улсын секторт хамааралтай гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс ТБХ 32-т тусгагдсан тодорхойлолт ба тайлбарыг УСНББОУС 31-д мөрдөх заавар удирдамж байдлаар тусган оруулсан. Энэхүү мөрдөх заавар удирдамж нь УСНББОУС 31-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон тэдгээр нь УСНББОУС 31-тэй хэрхэн уялдахыг харуулдаг ТБХ 32-ын Хавсралтыг үлгэрчилсэн жишээнд тусган оруулсан.
- ДҮ7. Энэ Стандарт нь хүлэмжийн хийн арилжааны схемийг<sup>2</sup> авч үздэггүй. Засгийн газрын тогтоосон хүлэмжийн хийн арилжааны схем нь хууль тогтоомж, дүрэм буюу адилтгах арга хэрэгслээр олгодог бүрэн эрх ба эрхийн нэг төрөл бөгөөд энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн (ДҮЗ-р параграфыг үзнэ үү). Засгийн газар нь хүлэмжийн хийн арилжааны схемийн дагуу зөвшөөрлийг худалдан авч болох юм. Ийм зөвшөөрлийг тайлагнах арга хандлагыг олон улсын болон үндэсний стандарт тогтоох зарим байгууллагууд одоогоор судлаж байгаа бөгөөд нягтлан болох бүртгэлийн тохиромжтой

---

<sup>2</sup> Emission trading schem-Хүлэмжийн хийн арилжааны схем. Энэ нь агаарын бохирдол, дулаан ялгаруулалтыг бууруулахын тулд эдийн засгийн урамшуулал олгосноор бохирдлыг хянах зах зээлд суурилсан хандлага юм байна. Агаар бохирдуулалт, дулаан ялгаруулалтанд хязгаар тогтоож, уг хязгаараас бага байгаа улс орон буюу аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох, харин тогтоосон хязгаараас илүү хэмжээний агаар бохирдуулах, дулаан ялгаруулах зайлшгүй шаардлагатай бол төлбөр төлөх, зөвшөөрлийг худалдан авах байдлаар уг схем ажилладаг. Ред.Ч.Д.

аргын хувьд нэгдсэн зөвшилцөлд хүрээгүй байна. УСНББОУСЗ нь хүлэмжийн хийн арилжааны схемд энэ Стандартын мөрдөгдөх боломжит байдлыг хэрэв шаардагатай бол дахин харгалзан авч үзнэ.

### **Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биет бус хөрөнгө**

ДҮ8. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүсэж буй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт, анхны хэмжилт ба тодруулгыг УСНББОУС 23-д заасан байдаг. УСНББОУС 23 нь биет бус хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмших нөхцөл байдлуудыг авч үздэг. Ийм ажил гүйлгээнээс үүсэх биет бус хөрөнгийн хувьд байгууллага нь биет бус хөрөнгийн анхны хэмжилтэнд хамаарах УСНББОУС 23-ын шаардлагуудыг энэ Стандартын шаардлагын хамтаар мөрдөх ба ингэснээр энэ Стандартад тусгайлан заасан, шууд хамааруулан хуваарилж болох өртөг зардлыг харгалзан үзэхийг УСНББОУСЗ зөвшөөрсөн.

### **Дахин үнэлгээний загвар**

ДҮ9. УСНББОУС 31-д санал болгосон дахин үнэлгээний загвар нь дахин үнэлгээг хөрөнгө нэг бүрээр тайлагнахыг шаарддаг НББОУС 38-д заасан загвартай төсөөтэй юм. УСНББОУС 17, *Үндсэн хөрөнгө* нь дахин үнэлгээг бие даасан хөрөнгөөр биш, харин хөрөнгүүдийн ангиар тайлагнахыг шаарддаг. УСНББОУСЗ нь энэхүү арга хандлагыг биет бус хөрөнгийн хувьд харгалзан үзсэн боловч биет бус хөрөнгүүд нь ижил төсөөтэй байх магадлал багатай бөгөөд үндсэн хөрөнгөөс өөр тул ингэж шаардлагагүй гэж дүгнэсэн. Улсын секторын байгууллагуудын биет бус хөрөнгийн гол төрлүүдийн нэг нь дотооддоо бий болгосон программ хангамж бөгөөд тэдгээрийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг бие даасан хөрөнгө нэг бүрээр бэлтгэх боломжтой байдаг. Иймээс УСНББОУСЗ нь дахин үнэлсэн биет бус хөрөнгийг хөрөнгө тус бүрээр тайлагнахыг шаардах нь тохиромжтой гэж үзсэн.

### **2013 оны 12 дугаар сар, 2014 оны 5 дугаар сард гаргасан, НББОУСЗ-ийн СТОУС-ын Сайжруулалтууд ба Цар Хүрээний Цөөн Нэмэлт Өөрчлөлтүүдийн үр дүнд УСНББОУС 31-д хийсэн хянан засварлалт**

ДҮ10. УСНББОУСЗ нь 2013 оны 12 дугаар сар, 2014 оны 5 дугаар сард НББОУСЗ-өөс гаргасан *СТОУС-ын Сайжруулалтууд* болон *Элэгдэл, Хорогдуулгын Хүлээн Зөвшөөрөгдөх Аргуудын Тодруулга*-д тусгасан, НББОУС 38-ын хянан засварлалтыг нягталж шалгаад уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж ерөнхийдөө санал нэгдсэн.

### **УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд-ын Хэсэг II: “Санал гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд”-ын үр дүнд УСНББОУС 31-д хийсэн хянан засварлалт**

ДҮ11. Санал гаргагчид нь борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба данснаас хасах бүлгийг УСНББОУС тууштай бус илэрхийлсэн

гэж үзсэн. СТОУС 5, *Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа* нь дараах учир шалтгааны улмаас зөвхөн зарим нөхцөл байдалд улсын секторт тохиромжтой байж болох юм гэж УСНББОУСЗ дүгнэсэн:

- (а) Шаардлагатай түвшний зөвшөөрлийн улмаас улсын секторт хөрөнгийн борлуулалтыг нэг жилийн дотор хийж чадахгүй байж болох юм. Энэ нь СТОУС 5-ын дагуу тусгах мэдээллийн хамааралтай ба тууштай байдалд эргэлзээ үүсгэдэг. Тухайлбал; борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг СТОУС 5-ын дагуу элэгдүүлэхгүй гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Хөрөнгийг урт хугацаанд элэгдүүлэхгүй байх нь тохиромжгүй гэж УСНББОУСЗ үзэж байна.
- (б) Улсын секторт олон хөрөнгийг үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр шилжүүлэх буюу түгээн хуваарилах замаар данснаас хасдаг. СТОУС 5 нь бодит үнэ цэнээр хийх борлуулалтыг авч үздэг тул түүний хэмжилт ба тодруулгын шаардлагууд нь ийм шилжүүлэлтийн хувьд холбогдох мэдээллээр хангадаггүй. Гэвч борлуулалтыг бодит үнэ цэнээр хийх санаа зорилготой байх тохиолдолд СТОУС 5-ын хэмжилт ба тодруулгын шаардлагууд нь тохиромжтой байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг.
- (в) Улсын сектор дахь зогсоосон олон үйл ажиллагаа нь үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр өмнө үзүүлсэн үйлчилгээ байдаг. СТОУС 5 нь данснаас хасах эсвэл борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж дахин ангилахаас өмнө мөнгө бий болгогч нэгжүүд буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг байсан, тийм зогсоосон үйл ажиллагааг авч үздэг тул түүний тодруулгын шаардлагууд нь улсын секторын зогсоосон үйл ажиллагааны хувьд холбогдох мэдээллээр хангадаггүй байж болох юм. Гэвч зогсоосон үйл ажиллагаа нь өмнө нь мөнгө бий болгогч нэгжүүд буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн нэг болон хэд хэдэн бүлгүүд байсан бол СТОУС 5-ын тодруулгын шаардлагууд тохиромжтой байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг.

СТОУС 5 нь зөвхөн цөөн хязгаарлагдмал нөхцөл байдалд улсын секторт тохиромжтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн учраас борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагааг авч үзэх олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартуудын талаархи УСНББОУС дахь хэллэг лавлагааг хасахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Ийм хэллэг лавлагааг хасалгүй үлдээх нь СТОУС 5-ын шаардлагууд тохиромжгүй байж болох нөхцөл байдалд байгууллагууд түүний шаардлагуудыг даган мөрдөхөд хүргэнэ гэж УСНББОУСЗ санаа зовж байсан. УСНББОУС-уудад тусгайлан авч үзээгүй ажил гүйлгээний хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох заавар удирдамжаар УСНББОУС 3 хангана гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Тохиромжтой гэж тухайн байгууллага үзсэн тохиолдолд СТОУС 5-тай нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тэдгээр байгууллагууд баримтлахыг ийм заавар удирдамжаар зөвшөөрсөн байдаг.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 31-д хийсэн хянан засварлалт**

ДҮ2. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## ҮЛГЭРЧИЛСЭН ЖИШЭЭ

### АГУУЛГА

Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	Параграф ҮЖ1-ҮЖ5
Энэ Стандартын 63-р параграфыг мөрдөх жишээ	ҮЖ1-ҮЖ4
Энэ Стандартын 55-65-р параграфыг мөрдөх жишээ	ҮЖ5
Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг үнэлэх	ҮЖ6-ҮЖ21
Олж эзэмшсэн, тодорхой ашиглалтын хугацаатай патент	ҮЖ8-ҮЖ9
Олж эзэмшсэн, тодорхой бус ашиглалтын хугацаатай патент	ҮЖ10-ҮЖ11
50 жилийн үлдсэн хуулийн хугацаатай, олж эзэмшсэн зохиогчийн эрх	ҮЖ12-ҮЖ13
Олж эзэмшсэн өргөн нэвтрүүлгийн лиценз, таван жилийн дараа хугацаа дуусах – Хэсэг А	ҮЖ14-ҮЖ15
Олж эзэмшсэн өргөн нэвтрүүлгийн лиценз, таван жилийн дараа хугацаа дуусах – Хэсэг Б	ҮЖ16-ҮЖ17
Хоёр хотын хооронд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх, олж эзэмшсэн эрх - гурван жилийн дараа хугацаа дуусах	ҮЖ18-ҮЖ19
Үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн талаархи олж эзэмшсэн жагсаалт	ҮЖ20-ҮЖ21
Мөрдөх заавар удирдамжийг үлгэрчлэн харуулах жишээ	ҮЖ22

## Үлгэрчилсэн жишээ

*Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 31-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт**

*Энэ Стандартын 63-р параграфыг мөрдөх жишээ*

- ҮЖ1. Байгууллага нь шүүхээр шийдвэрлүүлэх зарга маргааны хуваарилалтыг илүү үр дүнтэй болгохын тулд шинэ системийг боловсруулсан бөгөөд энэ нь үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх үр дүнтэй байна. 20X8 оны 3 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилийн туршид уг системийн хөгжүүлэлтэнд зарцуулсан зарлага нь 1,000 ТН<sup>3</sup> байсан бөгөөд үүний 900 ТН нь 20X8 оны 3 дугаар сарын 01-нээс өмнө, харин 100 ТН нь 20X8 оны 3 дугаар сарын 01-нээс 20X8 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хоорондох хугацаанд гарсан. Шинээр боловсруулсан систем нь 20X8 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан гэдгийг тухайн байгууллага нь батлан харуулах боломжтой байна. Тус системийн нөхөгдөх үйлчилгээний дүнг (үүн дотроо, системийг ашиглахад бэлэн болгохоос өмнө тэрхүү хөгжүүлэлтийг бүрэн дуусгах ирээдүйн мөнгөн зарлага) 500 ТН гэж тооцоолсон.
- ҮЖ2. Тус боловсруулсан системийг тухайн санхүүгийн жилийн эцэст 100 ТН-ийн өртгөөр (хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангасан өдөр, өөрөөр хэлбэл 20X8 оны 3 дугаар сарын 01-нээс хойш гарсан зарлагаар) биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн. 20X8 оны 3 дугаар сарын 01-нээс өмнө хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй байсан учраас 20X8 оны 3 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд гарсан 900 ТН-ийн зарлагыг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Энэ зарлага нь санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн уг системийн өртгийн нэг хэсэг болохгүй.
- ҮЖ3. 20X9 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн туршид гарсан зарлага нь 2,000 ТН байна. Энэхүү санхүүгийн жилийн эцэст уг системийн нөхөгдөх үйлчилгээний дүнг (үүн дотроо, системийг ашиглахад бэлэн болгохоос өмнө тэрхүү хөгжүүлэлтийг бүрэн дуусгах ирээдүйн мөнгөн зарлага) 1,900 ТН гэж тооцоолсон.
- ҮЖ4. 20X9 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар уг боловсруулсан системийн өртөг нь 2,100 ТН (20X8 оны эцэст хүлээн зөвшөөрсөн 100 ТН-ийн зарлага дээр 20X9 оны санхүүгийн жилд хүлээн зөвшөөрсөн 2,000 ТН-ийн зарлагыг нэмсэн дүн) байв. Байгууллага нь үнэ цэнийн бууралтын гарзын өмнөх уг боловсруулсан системийн дансны үнийг (2,100 ТН) түүний нөхөгдөх үйлчилгээний дүнтэй (1,900 ТН) тохируулахын тулд 200 ТН-ийн үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрсөн. УСНББОУС 21-д заасан,

---

<sup>3</sup> Энэ Стандартад мөнгөн дүнг “тоолох нэгж (ТН)” гэж тэмдэглэсэн.



үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах шаардлага хангагдаж байвал энэхүү үнэ цэнийн бууралтын гарзыг дараагийн тайлант үед буцаана.

*Энэ Стандартын 55-65-р параграфыг мөрдөх жишээ*

ҮЖ5. Байгууллага нь дотооддоо ашиглах болон гуравдагч этгээдэд борлуулах зорилгоор статистик тайлан бэлтгэх системийг хөгжүүлэн боловсруулж байна. Энэ систем нь техникийн хувьд хэрэгжих боломжтой, ийм төрлийн тайлан эрэлттэй бөгөөд гуравдагч тал уг бүтээгдэхүүний төлөө төлбөр төлөхөд бэлэн байгаа, иймээс ирээдүйн магадлалт эдийн засгийн үр өгөөж бий болгоно гэдгийг тус байгууллага мэдэж байна. Уг системийн хөгжүүлэлтэнд хамаарах өртөг зардлыг найдвартай тодорхойлж, хэмжиж чадна.

**Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг үнэлэх**

ҮЖ6. Дараах заавар удирдамж нь биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг энэ Стандартын дагуу тодорхойлох жишээгээр хангана.

ҮЖ7. Дараах жишээ нэг бүр нь олж эзэмшсэн биет бус хөрөнгө, хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлохтой холбоотой баримт материал ба нөхцөл байдлууд, ийм тодорхойлолтод үндэслэсэн дараагийн тайлант үеийн нягтлан бодох бүртгэлийг тусган илэрхийлнэ.

*Олж эзэмшсэн, тодорхой ашиглалтын хугацаатай патент*

ҮЖ8. А байгууллага нь өөрийн үйлчлүүлэгчдийг үнэ төлбөргүй вакцинаар хангах өөрийн чадвар, боломжийг хадгалахын тулд Б байгууллагаас вакцины жорын патентыг худалдан авчээ. Патентаар хамгаалагдсан вакцин нь хамгийн наад зах нь 15 жилийн хугацаанд үйлчилгээний чадавхийг бий болгож чадна гэж хүлээгдэж байна. Патентыг олж эзэмших өдрөөрх түүний бодит үнэ цэнийн 60 хувиар уг патентыг таван жилийн дараа худалдан авах баталгааг А байгууллага нь В байгууллагаас хүлээн авсан бөгөөд А байгууллага нь уг патентыг таван жилийн дараа борлуулах санаа зорилготой байна.

ҮЖ9. Патент нь түүнийг олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнийн 60 хувьтай тэнцүү үлдэх өртөгтэй бөгөөд А байгууллагад ашиглагдах таван жилийн хугацаанд патентыг хорогдуулна. Мөн патентын үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 21-ийн дагуу сорьж шалгана.

*Олж эзэмшсэн, тодорхой бус ашиглалтын хугацаатай патент*

ҮЖ10. А байгууллага нь үйлчлүүлэгчдийг үнэ төлбөргүй вакцинаар хангах өөрийн чадвар, боломжийг хадгалахын тулд Б байгууллагаас вакцины жорын патентыг худалдан авчээ. Жорын патентын үр ашигт байдлыг хадгалахын тулд 10 жил тутамд бага хэмжээний өөрчлөлт сайжруулалт хийх шаардлагатай гэж үзэж байна. Патентын байнгын шинэчлэл өөрчлөлтийг дэмжих нотолгоо байгаа. Б байгууллага нь жорын үр ашигт байдлыг тасралтгүй хэвийн хадгалах ба үүнийг гүйцэтгэх өөрийн чадвар боломжийг

дэмжин нотлох гэрээг А байгууллага нь Б байгууллагатай байгуулсан. Патентыг шинэчлэх ба жорын үр ашигт байдлыг хадгалах өртөг зардал нь их дүнтэй биш байхаар хүлээгдэж байгаа бөгөөд сайжруулалт хийгдсэн үед Б байгууллагад төлөх юм.

ҮЖ11. Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн судалгааны шинжилгээ, хүн ам зүйн болон хүрээлэн буй орчны хандлага нь тус патент өөрийн вакцинжуулах хөтөлбөрийг тодорхой бус хугацаагаар хэрэгжүүлэх боломжийг олгосноор А байгууллагад үйлчилгээний чадавхи бүрдүүлнэ гэсэн нотолгоогоор хангадаг. Ингэснээр уг патентыг тодорхой бус ашиглалтын хугацаатай гэж үзнэ. Иймээс патентын ашиглалтын хугацааг тодорхой гэж тодорхойлох хүртэл уг патентыг хорогдуулахгүй. Мөн патентын үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 21-ийн дагуу сорьж шалгана.

*50 жилийн үлдсэн хуулийн хугацаатай, олж эзэмшсэн зохиогчийн эрх*

ҮЖ12. А байгууллага нь зохиогчийн эрх бүхий материалыг үйлдвэрлэж, өөрийн үйлчлүүлэгчдэд өртөг-нөхөх сууриар борлуулах боломжийг түүнд олгох зохиогчийн эрхийг Б байгууллагаас худалдаж авсан. Тухайн байгууллагын үйлчлүүлэгчдийн тогтсон дадал зуршил болон бусад хандлагын шинжилгээ нь уг зохиогчийн эрх бүхий материал ердөө 30 гаруй жилийн хугацаанд цэвэр мөнгөн орлогын гүйлгээ бий болгоно гэсэн нотолгоогоор хангадаг.

ҮЖ13. Уг зохиогчийн эрхийг түүний 30 жилийн тооцоолсон ашиглалтын хугацаанд хорогдуулна. Мөн зохиогчийн эрхийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 21-ийн дагуу сорьж шалгана.

*Олж эзэмшсэн өргөн нэвтрүүлгийн лиценз, таван жилийн дараа хугацаа дуусах – Хэсэг А*

ҮЖ14. А байгууллага нь өргөн нэвтрүүлгийн лицензийг Б байгууллагаас худалдан авсан. А байгууллага нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг олон нийтэд үнэ төлбөргүй үзүүлэх санаа зорилготой байна. Хэрэв А байгууллага нь өөрийн үйлчилгээний хэрэглэгчдэд тус үйлчилгээг хамгийн наад зах нь дундаж түвшний чанартайгаар үзүүлэх ба холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлж байвал уг өргөн нэвтрүүлгийн лицензийг 10 жил тутамд шинэчлэн сунгаж болох юм. Лицензийг багахан зардал гаргаснаар тодорхой бус хугацаанд сунгасаар байж болох бөгөөд хамгийн сүүлийн худалдан авалтаас өмнө хоёр удаа шинэчлэн сунгаад байсан. А байгууллага нь лицензийг тодорхой бус хугацаанд шинэчлэн сунгасаар байх санаа зорилготой бөгөөд ингэх түүний чадвар, боломжийг дэмжих нотолгоо байгаа. Өмнөх түүхээс харахад, лицензийн шинэчлэн сунгалтын хувьд төвөгтэй шийдвэрлэх асуудал гардаггүй. Өргөн нэвтрүүлэгт ашигладаг технологийг ойрын ирээдүйд ямар нэг технологиор сольж орлуулах төлөвгүй байна. Иймээс тус лиценз нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг тодорхой бус хугацаанд үнэ төлбөргүй үзүүлэх А байгууллагын чадвар боломжид хувь нэмрээ оруулна гэж хүлээгдэж байна.

ҮЖ15. Б байгууллага нь өргөн нэвтрүүлгийн лицензийг олгох өөрийн бүрэн эрхийг биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөггүй. Өргөн нэвтрүүлгийн лиценз нь уг өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг тодорхой бус хугацаанд үнэ төлбөргүй үзүүлэх А байгууллагын чадвар боломжид хувь нэмрээ оруулахаар хүлээгдэж буй учраас А байгууллага нь тэрхүү лицензийг тодорхой бус ашиглалтын хугацаатай гэж үздэг. Иймээс лицензийн ашиглалтын хугацааг тодорхой гэж тодорхойлох хүртэл уг лицензийг хорогдуулахгүй. Мөн лицензийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 21-ийн дагуу сорьж шалгана.

*Олж эзэмшсэн өргөн нэвтрүүлгийн лиценз, таван жилийн дараа хугацаа дуусах – Хэсэг Б*

ҮЖ16. Лиценз олгох эрх бүхий байгууллага нь өргөн нэвтрүүлгийн лицензийг цаашид шинэчлэн сунгахгүй, харин лицензийг дуудлага худалдаагаар худалдахаар дараагийн тайлант үед шийдвэрлэжээ. Лиценз олгох эрх бүхий байгууллагын ийм шийдвэр гарах үед А байгууллагын өргөн нэвтрүүлгийн лиценз нь хугацаа дуусах хүртэл гурван жил үлдээд байсан. Тус лиценз нь түүний хугацаа дуусах хүртэл үйлчилгээний чадавхи бүрдүүлсэн хэвээр байна гэж А байгууллага үзэж байв.

ҮЖ17. Өргөн нэвтрүүлгийн лицензийг цаашид сунган шинэчлэхгүй учраас түүний ашиглалтын хугацаа нь тодорхой бус байхаа больсон. Иймээс А байгууллага нь уг олж эзэмшсэн лицензийг түүний үлдсэн гурван жилийн ашиглалтын хугацаанд хорогдуулах бөгөөд үнэ цэнийн бууралтыг нь УСНББОУС 21-ийн дагуу нэн даруй сорьж шалгана.

*Хоёр хотын хооронд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх, олж эзэмшсэн эрх - гурван жилийн дараа хугацаа дуусах*

ҮЖ18. А байгууллага нь хоёр хотын хооронд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх эрхийг Б байгууллагаас худалдан авсан ба энэ нь орлого бий болгодог. Нийтийн тээврийн эрхийг таван жил тутамд шинэчлэн сунгадаг бөгөөд А байгууллага нь эрхийг сунгахтай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмыг даган мөрдөх санаа зорилготой байна. Тээврийн үйлчилгээний эрхийг ихэвчлэн маш бага төлбөртэйгээр шинэчлэн сунгадаг бөгөөд түүхэн туршлагаас харахад, уг үйлчилгээний эрхийг эзэмшиж буй байгууллага нь холбогдох дүрэм, журмыг мөрдсөн тохиолдолд сунгалтыг хийдэг. А байгууллага нь нийтийн тээврийн үйлчилгээг тодорхой бус хугацаагаар үзүүлэхээр төлөвлөж байна. Эрэлт ба мөнгөн гүйлгээний шинжилгээ нь ийм таамаглалыг дэмжин баталдаг.

ҮЖ19. Нийтийн тээврийн үйлчилгээ нь А байгууллагад тодорхой бус хугацаанд мөнгөн орлогын гүйлгээ бий болгоно гэдгийг баримт материал ба нөхцөл байдал дэмжин харуулж байгаа учраас уг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой биет бус хөрөнгийг тодорхой бус ашиглалтын хугацаатай гэж үзнэ. Иймээс биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхой гэж тодорхойлох хүртэл түүнийг хорогдуулахгүй. Мөн биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 26-гийн дагуу жил бүр,

түүнчлэн үнэ цэнэ буурсан байж болох шинж тэмдэг илэрсэн аливаа тохиолдолд сорьж шалгана.

*Үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчдийн талаархи олж эзэмшсэн жагсаалт*

- ҮЖ20. Орон нутгийн эрх бүхий байгууллага (А байгууллага) нь үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хариуцдаг улсын секторын өөр нэгэн байгууллагаас (Б байгууллага) үл хөдлөх хөрөнгө эзэмшигчдийн жагсаалтыг худалдан авсан. Б байгууллага нь засгийн газрын өөр түвшинд хамаардаг бөгөөд А тайлагнагч байгууллагын нэг хэсэг биш юм. А байгууллага нь татварын орлого бий болгоход уг жагсаалтыг ашиглах санаа зорилготой байгаа бөгөөд тэрхүү худалдаж авсан жагсаалтан<sup>4</sup> дахь мэдээллээс хамгийн наад зах нь нэг жилийн хугацаанд, гэхдээ гурван жилээс хэтрэхгүй хугацаанд үр шим хүртэх боломжтой гэж үзэж байна.
- ҮЖ21. Үл хөдлөх хөрөнгө өмчлөгчдийн жагсаалтыг түүний ашиглалтын хугацааны талаархи А байгууллагын хамгийн сайн тооцоололд үндэслэн, жишээлбэл 18 сарын хугацаанд хорогдуулна. Хэдийгээр Б байгууллага нь үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчдийн нэрс болон бусад мэдээллийг уг жагсаалтад ирээдүйд нэмж оруулах санаа зорилготой байж болох боловч тэрхүү олж эзэмшсэн жагсаалтаас А байгууллагад орох хүлээгдэж буй үр өгөөж нь А байгууллага түүнийг олж авсан өдрөөр тухайн жагсаалтад тусгагдсан үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчидтэй зөвхөн холбоотой байна. Мөн үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчдийн жагсаалтын үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 21-ийн дагуу жил бүр, түүнчлэн үнэ цэнэ буурсан байж болох шинж тэмдэг илэрсэн аливаа тохиолдолд үнэлснээр сорьж шалгана.

**Мөрдөх заавар удирдамжийг үлгэрчлэн харуулах жишээ**

- ҮЖ22. Доорх хүснэгтийн зорилго нь МЗУ2-МЗУ3-р параграфт дурдсан үе шат бүрийн явцад гарсан зарлагын жишээг үлгэрчлэн харуулах ба тэдгээрийн утга агуулгыг тодруулахад туслахын тулд МЗУ4-МЗУ11-р параграфын мөрдөлтийг үлгэрчлэн харуулах явдал юм. Энэ нь гарч болох бүх зарлагын дэлгэрэнгүй шалгах хуудсыг бэлтгэх зорилгогүй болно.

---

<sup>4</sup> Орон нутгийн эрх бүхий байгууллага нь үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчид болон бусад мэдээллийг уг мэдээний баазад ирээдүйд нэмж оруулах санаа зорилготой байж болох боловч тэрхүү олж эзэмшсэн мэдээний баазын хүлээгдэж буй үр өгөөж нь түүнийг олж авсан өдрөөр тухайн мэдээний баазад тусгагдсан үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчидтэй зөвхөн холбоотой байна. Дараагийн тайлант үеүдийн нэмэгдэлтийг дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө гэж үзэх бөгөөд энэ Стандартын дагуу тайлагнана.

ЗАРЛАГЫН ҮЕ ШАТ/ШИНЖ ТӨРӨЛ	НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АРГА ХАНДЛАГА
<b>Төлөвлөлт</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Хэрэгжих боломжит байдлын судалгаа хийх;</li> <li>• Техник хэрэгслийн болон программ хангамжийн үзүүлэлтүүдийг тодорхойлох;</li> <li>• Хувилбар бүтээгдэхүүнүүд болон нийлүүлэгчдийг үнэлэх;</li> <li>• Хамгийн тохиромжтойг сонгох;</li> </ul>	<p>Гарсан үед нь энэ Стандартын 52-р параграфын дагуу зардал гэж хүлээн зөвшөөрөх.</p>
<b>Хэрэглээний программууд ба Дэд бүтцийн хөгжүүлэлт</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Техник хэрэгслийг худалдан авах буюу хөгжүүлэх;</li> <li>• Домэйн нэр авах;</li> <li>• Үйлдлийн программ хангамжийг хөгжүүлэх (жишээлбэл; үйлдлийн системийн болон серверийн программ хангамж);</li> <li>• Хэрэглээний программын кодыг боловсруулах;</li> <li>• Боловсруулсан хэрэглээний программыг суулгах;</li> <li>• Ачаалал даах чадварыг сорьж шалгах.</li> </ul>	<p>УСНББОУС 17-гийн шаардлагуудыг мөрдөх.</p> <p>Удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулахын тулд вэб сайтыг бэлтгэх ажиллагаанд зарлагыг шууд хамааруулж болох бөгөөд уг вэб сайт нь энэ Стандартын 28 ба 55<sup>5</sup>-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байхаас бусад тохиолдолд зарлагыг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.</p>
<b>График дизайны хөгжүүлэлт</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Вэб сайтын харагдах байдлыг зохиомжлох (жишээлбэл; харагдах хэлбэр, өнгө);</li> </ul>	<p>Удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулахын тулд вэб сайтыг бэлтгэх ажиллагаанд зарлагыг шууд хамааруулж болох бөгөөд уг вэб сайт нь энэ Стандартын 28 ба 55<sup>6</sup>-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байхаас бусад тохиолдолд зарлагыг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.</p>

<sup>5</sup> Зөвхөн тухайн байгууллагын өөрийн бүтээгдэхүүн ба үйлчилгээг ихэвчлэн сурталчлах, урамшуулах буюу түүний талаар нийт олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор вэб сайтыг хөгжүүлэхэд гаргасан бүх зарлагыг энэ Стандартын 66-р параграфын дагуу гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.

<sup>6</sup> Өмнөх хөлийн тэмдэглэлийг үзнэ үү.

<b>Контентын хөгжүүлэлт</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Текстэн буюу графикан мэдээллийг үүсгэх, худалдан авах, бэлтгэх (жишээлбэл; холбоос ба түлхүүр үгийг үүсгэх) ба вэб сайтын хөгжүүлэлтийг дуусгахаас өмнө тухайн вэб сайтад ачаалан байршуулах. Контентын жишээнд тухайн байгууллагын үйлчилгээ буюу бүтээгдэхүүн, захиалагчийн хандан нэвтэрдэн сэдвийн талаархи мэдээлэл хамаарна.</li> </ul>	<p>Байгууллагын өөрийн үйлчилгээ болон бүтээгдэхүүнийг (жишээлбэл; бүтээгдэхүүний цахим фото зураг) сурталчлах буюу дэмжин урамшуулахын тулд уг контентыг хөгжүүлэн боловсруулсан тохиолдолд зарлагыг энэ Стандартын 67(в) параграфын дагуу гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө. Харин удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулахын тулд вэб сайтыг бэлтгэх ажиллагаанд зарлагыг шууд хамааруулж болох бөгөөд уг вэб сайт нь энэ Стандартын 28 ба 55<sup>7</sup>-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байхаас бусад тохиолдолд зарлагыг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.</p>
<b>Үйл ажиллагаа</b>	
<ul style="list-style-type: none"> <li>Графикийг шинэчлэн баяжуулах ба контентыг засварлан өөрчлөх;</li> <li>Шинэ чиг үүрэг, шинжүүд болон контентыг нэмж оруулах;</li> <li>Хайлтын хөтлөгчдөд вэб сайтыг бүртгүүлэх;</li> <li>Мэдээг нөөцлөн хадгалах;</li> <li>Аюулгүй хандан нэвтрэлтийг шалгах; ба</li> <li>Вэб сайтын ашиглалтыг шинжлэх.</li> </ul>	<p>Энэ Стандартын 28-р параграфт заасан биет бус хөрөнгийн тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж буй эсэхийг үнэлэх ба ингэж байгаа тохиолдолд зарлагыг уг вэб сайтын дансны үнэд хүлээн зөвшөөрнө.</p>

<sup>7</sup> Өмнөх хөлийн тэмдэглэлийг үзнэ үү.

<b>Бусад</b>	
<ul style="list-style-type: none"> <li>• Удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулахын тулд вэб сайтыг бэлтгэх ажиллагаанд шууд хамааруулж болохоос бусад, борлуулалтын, захиргааны болон ерөнхий удирдлагын нэмэгдэл зардал;</li> <li>• Вэб сайт нь төлөвлөсөн гүйцэтгэлд хүрэхийн өмнө гарсан үйл ажиллагааны эхний алдагдал ба илт ойлгомжтой тогтоон тодорхойлсон үр ашиггүй байдал (жишээлбэл; туршилтын байдлаар ажиллуулах үеийн сорил шалгалт); ба</li> <li>• Вэб сайтыг ажиллуулах ажилтнуудыг сургах.</li> </ul>	<p>Гарсан үед нь энэ Стандартын 63-69-р параграфын дагуу зардал гэж хүлээн зөвшөөрөх.</p>

## НББОУС 38-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийг НББОУС 38, *Биет Бус Хөрөнгө*-өөс (2008 оны 12 дугаар сарын 31-нээрх) үндсэндээ бэлтгэсэн болно. УСНББОУС 31 ба НББОУС 38-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 31 нь хууль тогтоомж, дүрэм буюу адилтгах арга хэрэгслээр олгосон бүрэн эрх ба эрхийг өөрийн цар хүрээнд хамруулдаггүй.
- УСНББОУС 31 нь холбогдох нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үлгэрчлэн харуулахын тулд Тайлбарын Байнгын Хорооны Тайлбар 32, *Биет Бус Хөрөнгө-Вэб Сайтын Өртөг*-т тусгагдсан заавар удирдамжийг Мөрдөх заавар удирдамж байдлаар тусган оруулсан.
- УСНББОУС 31 нь биет бус соёлын өв хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийг шаарддаггүй буюу хориглодоггүй. Биет бус соёлын өв хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг байгууллага нь хүлээн зөвшөөрсөн тэдгээр биет бус соёлын өв хөрөнгийн хувьд энэ Стандартын тодруулгын шаардлагуудыг даган мөрдөх ёстой боловч тэдгээр биет бус соёлын өв хөрөнгийн хувьд энэ Стандартын бусад шаардлагуудыг даган мөрдөхгүй байж болох буюу даган мөрдөх албагүй юм. НББОУС 38-д үүнтэй адилтгах заавар удирдамж байдаггүй.
- НББОУС 38 нь засгийн газрын буцалтгүй тусламжаар олж эзэмшсэн биет бус хөрөнгийн талаархи заавар удирдамжийг агуулсан байдаг. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийг илэрхийлэхийн тулд энэхүү заавар удирдамжид УСНББОУС 31-ийн 31-р параграфар засвар өөрчлөлт оруулсан. Биет бус хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд өртөг нь уг олж эзэмшсэн өдрөөрх түүний бодит үнэ цэнэ байна гэж УСНББОУС 31-д заасан.
- Солилцооны ажил гүйлгээ нь арилжааны мөн чанаргүй байх үеийн хөрөнгийн солилцооны талаархи заавар удирдамжийг НББОУС 38-д тусгасан байдаг. УСНББОУС 31 нь ийм заавар удирдамжийг тусгаагүй байдаг.
- Улсын секторын нөхцөл байдлуудыг илүү сайн авч үзэхийн тулд НББОУС 38-ын жишээнүүдэд засвар өөрчлөлт оруулсан.
- УСНББОУС 31 нь зарим тохиолдолд НББОУС 38-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь “орлого” /revenue/, “санхүүгийн үр дүнгийн тайлан”, “ашиг, алдагдал” /surplus or deficit/, “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи”, “хуримтлагдсан ашиг, алдагдал” /accumulated surpluses or deficit/, “ажиллагаа/үйл ажиллагаа”, “заавал биелүүлэх хэлцлээс үүссэн эрх (үүн дотроо, гэрээний буюу хуулийн бусад эрх)”, “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 38 дахь адилтгах нэр томъёо нь “орлого” /income/, “дэлгэрэнгүй орлогын тайлан”, “ашиг, алдагдал” /profit or loss/, “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж”, “хуримтлагдсан ашиг” /retained earnings/, “бизнес”, “гэрээний буюу хуулийн бусад эрх”, “өмч” юм.



## УСНББОУС 32–ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) нь үйлчилгээний концессын хэлцэл дэх эрх бүхий этгээдийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг тогтооно. Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хорооноос боловсруулж, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУС3)-өөс хэвлэн гаргасан Тайлбар 12 (СТОУТХ 12), *Үйлчилгээний Концессын Хэлцэл*-ээс үүнийг хялбаршуулан гаргасан болно. СТОУТХ 12 нь үйлчилгээний концессын хэлцэл дэх эзэмшигчийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг тогтоодог. Энэхүү УСНББОУС нь Тайлбарын Байнгын Хорооноос боловсруулж, НББОУС3-өөс хэвлэн гаргасан Тайлбар 29 (ТБХ 29), *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Тодруулга*-аас авсан ишлэлүүдийг мөн тусган агуулсан байдаг. СТОУТХ 12 болон ТБХ 29-өөс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУС3)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУС3-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУС3-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 32-ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл-ийг 2011 оны 10 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 31-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 32-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
13	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
32	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
33	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
35	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
35А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
35Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
36А	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
36Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
36В	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

37	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
МЗУ20	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
МЗУ35	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
МЗУ68	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
МЗУ69	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
МЗУ70	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
МЗУ71	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
МЗУ72	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
МЗУ73	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

2011 оны 10 дугаар сар

**УСНББОУС 32–ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ  
БҮХИЙ ЭТГЭЭД**

**АГУУЛГА**

---

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-7
Тодорхойлолт	8
Үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	9-13
Өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	14-28
Санхүүгийн өр төлбөрийн загвар	18-23
Концесс эзэмшигчид эрх олгох загвар	24-26
Хэлцлийг хуваах	27-28
Бусад өр төлбөр, үүрэг амлалт, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө	29
Бусад орлого	30
Толилуулга ба тодруулга	31-33
Шилжилтийн нөхцөл	34-35
Хүчин төгөлдөр болох хугацаа	36-37
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
Үлгэрчилсэн жишээ	

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх Бүхий Этгээд*-ийг 1-37-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 32-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь улсын секторын байгууллага болох эрх бүхий этгээдийн үйлчилгээний концессын хэлцлийн тайлагналыг тодорхойлоход оршино.

## Цар хүрээ (МЗУ1-МЗУ2-р параграфыг үзнэ үү)

2. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага<sup>1</sup> нь үйлчилгээний концессы хэлцлийн тайлагналд энэ Стандартыг мөрдөнө.
3. [Хассан]
4. [Хассан]
5. Энэ Стандартын цар хүрээнд хамаарах хэлцлүүд нь үйлчилгээний концессын хөрөнгөтэй холбоотойгоор эрх бүхий этгээдийн нэрийн өмнөөс төрийн үйлчилгээ үзүүлж буй эзэмшигчтэй холбоотой байна.
6. Төрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоогүй хэлцлүүд болон тухайн хөрөнгийг эрх бүхий этгээд хянадаггүй байх үеийн үйлчилгээ ба удирдлагын бүрэлдэхүүн хэсгүүдтэй (жишээлбэл; аутсорсинг, үйлчилгээний гэрээ, хувьчлалтай) холбоотой хэлцэл нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй хэлцэл юм.
7. Концесс эзэмшигчийн нягтлан бодох бүртгэлийг энэ Стандартад заагаагүй болно (концесс эзэмшигчийн үйлчилгээний концессын хэлцлийн тайлагналын талаархи заавар удирдамжийг үйлчилгээний концессын хэлцлийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартаас үзэж болно).

## Тодорхойлолт

8. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Энэ Стандартын зорилгын хувьд заавал биелүүлэх хэлцэл нь хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адилтгах эрх, үүргийг бий болгодог гэрээ болон бусад хэлцлийг илэрхийлнэ.

Энэ Стандартын зорилгын хувьд эрх бүхий этгээд гэдэг нь үйлчилгээний концессын хөрөнгийг ашиглах эрхийг эзэмшигчид олгодог байгууллага юм.

Энэ Стандартын зорилгын хувьд эзэмшигч гэдэг нь эрх бүхий этгээдийн зүгээс хөрөнгөнд тавих хяналтан дор төрийн үйлчилгээг

---

<sup>1</sup> Энэ Стандартын зорилгын хувьд байгууллага гэдэг нь эрх бүхий этгээдийг илэрхийлнэ.

**үзүүлэхийн тулд уг үйлчилгээний концессын хөрөнгийг ашиглаж буй байгууллага юм.**

**Үйлчилгээний концессын хэлцэл гэдэг нь дараах нөхцөлтэйгээр эрх бүхий этгээд ба эзэмшигчийн хооронд байгуулсан заавал биелүүлэх хэлцэл юм:**

- (a) Эзэмшигч нь эрх бүхий этгээдийн нэрийн өмнөөс төрийн үйлчилгээг үзүүлэхийн тулд уг үйлчилгээний концессын хөрөнгийг тодорхой хугацаанд ашиглах;
- (б) Үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд түүний үзүүлсэн үйлчилгээний төлөө эзэмшигчид төлбөр олгох.

**Үйлчилгээний концессын хөрөнгө гэдэг нь үйлчилгээний концессын хэлцлийн дагуу төрийн үйлчилгээ үзүүлэхэд ашигладаг дараах хөрөнгө юм. Үүнд:**

- (a) **Эзэмшигчийн нийлүүлдэг доорх хөрөнгө:**
  - (i) Эзэмшигч нь барьж байгуулсан, хөгжүүлсэн эсвэл гуравдагч талаас олж эзэмшсэн; эсвэл
  - (ii) Эзэмшигчид одоо байгаа хөрөнгө; эсвэл
- (б) **Эрх бүхий этгээдийн нийлүүлдэг доорх хөрөнгө:**
  - (i) Эрх бүхий этгээдэд одоо байгаа хөрөнгө; эсвэл
  - (ii) Эрх бүхий этгээдэд одоо байгаа хөрөнгөнд хийсэн сайжруулалт.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

**Үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт (МЗУ5-МЗУ35-р параграфыг үзнэ үү)**

9. Дараах тохиолдолд эрх бүхий этгээд нь эзэмшигчийн нийлүүлсэн хөрөнгө ба өөрийн одоо байгаа хөрөнгийн сайжруулалтыг үйлчилгээний концессын хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө:
- (a) Эзэмшигч тухайн хөрөнгөөр ямар үйлчилгээг, хэнд, ямар үнээр үзүүлэхийг эрх бүхий этгээд нь хянадаг буюу зохицуулдаг; ба
  - (б) Эрх бүхий этгээд нь үр шимийг хүртэх эрх болон тухайн хэлцлийн хугацааны эцэст уг хөрөнгөнд үлдэх аливаа мэдэгдэхүйц хувь оролцоог өмчлөлөөр дамжуулан буюу өөр бусад арга замаар хянадаг.

10. Хэрэв 9(а) параграфт заасан нөхцөл хангагдаж байвал үйлчилгээний концессын хэлцэлд ашигладаг хөрөнгийн хувьд энэ Стандартыг түүний ашиглалтын хугацааны туршид (“ашиглалтын нийт хугацааны” хөрөнгөнд) мөрдөнө.
11. 12-р параграфт дурдсанаас бусад тохиолдолд эрх бүхий этгээд нь 9-р параграфын (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфын) дагуу хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний концессын хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр анх хэмжинэ.
12. Эрх бүхий этгээдийн одоо байгаа хөрөнгө нь 9(а) ба 9(б) параграфт (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфт) заасан нөхцлийг хангаж байвал уг эрх бүхий этгээд нь тэрхүү одоо байгаа хөрөнгийг үйлчилгээний концессын хөрөнгө гэж дахин ангилна. Дахин ангилсан үйлчилгээний концессын хөрөнгийг УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө* ба УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийн аль тохиромжтой Стандартын дагуу тайлагнана.
13. Анхны хүлээн зөвшөөрөлт буюу дахин ангиллын дараа, үйлчилгээний концессын хөрөнгийг УСНББОУС 17 ба УСНББОУС 31-ийн аль тохиромжтой Стандартын дагуу тайлагнана.

### **Өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт (МЗУ36-МЗУ50-р параграфыг үзнэ үү)**

14. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийг 9-р параграфын (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфын) дагуу хүлээн зөвшөөрсөн тохиолдолд уг эрх бүхий этгээд нь мөн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. 15-р параграфт дурдсанчлан, эзэмшигч нь нэмэлт төлбөр төлөх нөхцөл байдлаас бусад тохиолдолд эрх бүхий этгээдийн одоо байгаа хөрөнгийг 12-р параграфын дагуу үйлчилгээний концессын хөрөнгө гэж дахин ангилсан бол уг эрх бүхий этгээд нь өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.
15. 14-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг 11-р параграфын дагуу хэмжсэн үйлчилгээний концессын хөрөнгөтэй ижил дүнгээр анх хэмжих бөгөөд эрх бүхий этгээдээс эзэмшигчид эсвэл эзэмшигчээс эрх бүхий этгээдэд өгсөн аливаа бусад төлбөрийн (жишээлбэл; мөнгө) дүнгээр тохируулна.
16. Хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн шинж төрөл нь эрх бүхий этгээд ба эзэмшигчийн хооронд солилцсон төлбөрийн шинж төрөлд үндэслэдэг. Эрх бүхий этгээдээс эзэмшигчид өгсөн төлбөрийн шинж төрлийг тухайн заавал биелүүлэх хэлцлийн, хэрэв хамааралтай бол гэрээний хуулийн заалтуудыг лавлагаа болгосноор тодорхойлно.



17. Үйлчилгээний концессын хөрөнгийн солилцооны хувьд эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийн хариуд дараах зүйлсийг дурын хэлбэрээр хослуулан эзэмшигчид олгож болно:
- (а) Эзэмшигчид төлбөр төлөх (“санхүүгийн өр төлбөр”-ийн загвар);
  - (б) Доорх гэх мэт бусад арга хэрэгслээр эзэмшигчид нөхөн төлбөр олгох (“эзэмшигчид эрх олгох” загвар):
    - (i) Үйлчилгээний концессын хөрөнгийг гуравдагч талын хэрэглэгчид ашиглуулснаар орлого олох эрхийг уг эзэмшигчид олгох; эсвэл
    - (ii) Орлого бий болгох өөр бусад хөрөнгийг тухайн эзэмшигч ашиглах эрхийг түүнд олгох (жишээлбэл; эмнэлгийн барилгын нэг жигүүрийг хувийн компанид ашиглуулах ба эрх бүхий этгээд нь иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхийн тулд барилгын бусад үлдсэн хэсгийг ашиглах эсвэл нийтийн эзэмшлийн авто зогсоолын залгаа хэсгийг хувийн компанид зогсоол байдлаар ашиглуулах).

**Санхүүгийн өр төлбөрийн загвар (МЗУ37-МЗУ46-р параграфыг үзнэ үү)**

18. **Үйлчилгээний концессын хөрөнгийн барьж байгуулалт, хөгжүүлэлт, худалдан авалт буюу сайжруулалтын хариуд эрх бүхий этгээд нь тухайн эзэмшигчид мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг төлөх нөхцөлт бус үүрэгтэй тохиолдолд тухайн эрх бүхий этгээд нь 14-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн уг өр төлбөрийг санхүүгийн өр төлбөр гэж тайлагнана.**
19. Эрх бүхий этгээд нь дараах зүйлсийг уг эзэмшигчид төлөх баталгаа гаргасан бол тэрхүү эрх бүхий этгээд нь мөнгө төлөх нөхцөлт бус үүрэгтэй байна:
- (а) Тусгайлан заасан буюу тодорхойлж болох дүн; эсвэл
  - (б) Хэдийгээр төлбөр нь тухайн үйлчилгээний концессын хөрөнгө тусгайлан заасан чанарын буюу үр ашгийн шаардлагуудыг хангана гэсэн уг эзэмшигчийн баталгаанаас болзошгүй хамаарах байлаа ч гэсэн 19(а) параграфт дурдсан, тусгайлан заасан буюу тодорхойлж болох аливаа дүн ба төрийн үйлчилгээний хэрэглэгчдээс тэрхүү эзэмшигчийн хүлээн авсан дүн хоорондох аливаа дутуу зөрүү.
20. Энэ Стандарт нь шаардлагууд болон заавар удирдамжаар хангаснаас бусад тохиолдолд 14-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн хувьд УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*, УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагууд, УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ыг мөрдөнө.
21. **Эрх бүхий этгээд нь төлбөрүүдийг эзэмшигчид хуваарилж, 14-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн бууралт,**

санхүүгийн зардал, эзэмшигчийн үзүүлсэн үйлчилгээний төлбөр байдлаар тэдгээрийг холбогдох мөн чанарын дагуу тайлагнана.

22. 21-р параграфын дагуу тодорхойлсон бөгөөд үйлчилгээний концессын хэлцлээр эзэмшигчийн үзүүлсэн үйлчилгээний төлбөр ба санхүүгийн зардлыг зардал гэж тайлагнана.
23. Үйлчилгээний концессын хэлцлийн хөрөнгө ба үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгүүдийг тусад нь тодорхойлж болох тохиолдолд эрх бүхий этгээдээс эзэмшигчид төлсөн төлбөрийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгүүдийг тухайн үйлчилгээний концессын хөрөнгө ба үйлчилгээний харгалзах бодит үнэ цэнүүдийг лавлагаа болгосноор хуваарилна. Харин хөрөнгө ба үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгүүдийг тусад нь тодорхойлж болохгүй тохиолдолд эрх бүхий этгээдээс эзэмшигчид төлсөн төлбөрийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийг тооцооллын арга зүй ашигласнаар тодорхойлно.

**Концесс эзэмшигчид эрх олгох загвар (МЗУ47-МЗУ49-р параграфыг үзнэ үү)**

24. Үйлчилгээний концессын хөрөнгийн барьж байгуулалт, хөгжүүлэлт, худалдан авалт буюу сайжруулалтын хариуд эрх бүхий этгээд нь тухайн эзэмшигчид мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг төлөх нөхцөлт бус үүрэггүй бөгөөд гуравдагч талын хэрэглэгчдээс эсвэл орлого бий болгох бусад хөрөнгөөс орлого олох эрхийг тэрхүү эзэмшигчид олгодог тохиолдолд эрх бүхий этгээд нь 14-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг уг эрх бүхий этгээд ба эзэмшигчийн хоорондох хөрөнгийн солилцооноос үүссэн орлогын урьдчилж орсон хэсэг байдлаар тайлагнана.
25. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хэлцлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан орлогыг хүлээн зөвшөөрөх ба 24-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг бууруулна.
26. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгө буюу орлого бий болгодог бусад хөрөнгийг гуравдагч талын хэрэглэгчдэд ашиглуулснаар орлого олох эрхийг эзэмшигчид олгосноор тухайн үйлчилгээний концессын хөрөнгө болон үзүүлсэн үйлчилгээний хариуд эзэмшигчид нөхөн төлбөр олгодог тохиолдолд уг солилцоог орлого бий болгодог ажил гүйлгээ гэж үзнэ. Эзэмшигчид олгож буй эрх нь үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд хүчин төгөлдөр байх тул эрх бүхий этгээд нь уг солилцооноос бий болсон орлогыг нэн даруй хүлээн зөвшөөрөхгүй. Харин хараахан хэрэгжээгүй байгаа орлогын аливаа хэсгийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Орлогыг үйлчилгээний концессын хэлцлийн эдийн засгийн мөн чанарын дагуу хүлээн зөвшөөрөх ба орлогыг хүлээн зөвшөөрсөн хэмжээгээр өр төлбөрийг бууруулна.

**Хэлцлийг хуваах (МЗУ50-р параграфыг үзнэ үү)**

27. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийн барьж байгуулалт, хөгжүүлэлт, худалдан авалт буюу сайжруулалтын

төлбөрийн зарим хэсгийг санхүүгийн өр төлбөр гаргаснаар, зарим хэсгийг уг эзэмшигчид эрх олгох замаар барагдуулдаг бол 14-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн нийт өр төлбөрийн хэсэг нэг бүрийг тусад нь тайлагнах шаардлагатай. Нийт өр төлбөрийн хувьд анх хүлээн зөвшөөрсөн дүн нь 15-р параграфт заасан дүнтэй ижил байна.

28. Эрх бүхий этгээд нь 27-р параграфт дурдсан өр төлбөрийн хэсэг нэг бүрийг 18-26-р параграфын дагуу тайлагнана.

### **Бусад өр төлбөр, үүрэг амлалт, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө (МЗУ51-МЗУ54-р параграфыг үзнэ үү)**

29. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хэлцлээс үүссэн бусад өр төлбөр, үүрэг амлалт, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгийг УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*, УСНББОУС 28, УСНББОУС 29, УСНББОУС 30-ын дагуу тайлагнана.

### **Бусад орлого (МЗУ55–МЗУ64-р параграфыг үзнэ үү)**

30. Эрх бүхий этгээд нь 24-26-р параграфт дурдсанаас бусад, үйлчилгээний концессын хэлцлээс үүссэн орлогыг УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ын дагуу тайлагнана.

### **Толилуулга ба тодруулга (МЗУ65–МЗУ67-р параграфыг үзнэ үү)**

31. Эрх бүхий этгээд нь мэдээллийг УСНББОУС 1-ийн дагуу толилуулна.
32. Тодруулгад тусгах зохих тодруулгыг тодорхойлохдоо үйлчилгээний концессын хэлцлийн бүх төлөв байдлыг харгалзан үзнэ. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хэлцлийн хувьд дараах мэдээллийг тайлант үе бүрд тодруулна:
- (a) Хэлцлийн тайлбар тодорхойлолт;
  - (б) Ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн, хугацаа, магадлалд нөлөөлж болох уг хэлцлийн гол чухал нөхцлүүд (жишээлбэл; концессын хугацаа, дахин үнэ тогтоох өдрүүд, дахин үнэ тогтоолт буюу дахин хэлэлцэн тохиролцоонд баримтлах суурь үндэслэл);
  - (в) Доорх зүйлсийн шинж төрөл ба хэмжээ (жишээлбэл; тохиромжтой тоо хэмжээ, цаг хугацаа, мөнгөн дүн):
    - (i) Тусгайлан заасан хөрөнгийг ашиглах эрх;
    - (ii) Үйлчилгээний концессын хэлцэлтэй холбоотойгоор тохиролцсон үйлчилгээг үзүүлнэ гэж эзэмшигчээс хүлээх эрх;

- (iii) **Тухайн тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний концессын хөрөнгийн дансны үнэ, үүн дотроо үйлчилгээний концессын хөрөнгө гэж дахин ангилсан уг эрх бүхий этгээдийн одоо байгаа хөрөнгө;**
  - (iv) **Үйлчилгээний концессын хэлцлийн эцэст тухайн тодорхой хөрөнгийг хүлээн авах эрх;**
  - (v) **Шинэчлэн сунгах ба дуусгавар болгох сонголт;**
  - (vi) **Бусад эрх ба үүрэг (жишээлбэл; үйлчилгээний концессын хөрөнгийн их засвар);**
  - (vii) **Үйлчилгээний концессын хөрөнгө буюу орлого бий болгох бусад хөрөнгөнд хандан ашиглах эрхийг эзэмшигчид олгох үүрэг;**
- (г) **Тайлант үеийн туршид хэлцэлд хийгдсэн өөрчлөлтүүд.**
33. 32-р параграфтаар шаардсан тодруулгыг үйлчилгээний концессын материаллаг хэлцэл бүрийн хувьд тус тусад нь, эсвэл ижил төсөөтэй шинж төрөл бүхий үйлчилгээнүүдтэй (жишээлбэл; төлбөртэй авто замын хураамж цуглуулах, харилцаа холбооны буюу ус хангамжийн үйлчилгээ) холбоотой үйлчилгээний концессын хэлцлийн хувьд нийт дүнгээр нь хийнэ. УСНББОУС 17 ба/буюу УСНББОУС 31-д шаардсан тодруулгаас гадна энэхүү тодруулгыг хөрөнгийн ангиар хийнэ. Нэгтгэн нийлүүлж тайлагнадаг ижил төсөөтэй шинж чанар бүхий үйлчилгээний концессын хэлцэлд хамаарах үйлчилгээний концессын хөрөнгүүд нь УСНББОУС 17 ба/буюу УСНББОУС 31-ийн дагуу тодруулсан хөрөнгүүдийн дэд ангийг бүрдүүлж болох бөгөөд УСНББОУС 17 ба/буюу УСНББОУС 31-ийн дагуу тодруулсан хөрөнгүүдийн нэгээс олон ангид хамаарч болох юм. Жишээлбэл; УСНББОУС 17-гийн зорилгоор, төлбөртэй гүүрийг бусад гүүртэй ижил ангид оруулж болно. Энэ параграфын зорилгын хувьд, төлбөртэй авто зам гэж нэгтгэн нийлүүлж тайлагнасан үйлчилгээний концессын хэлцэлд төлбөртэй гүүрийг нэгтгэн оруулж болно.

## **Шилжилтийн нөхцөл**

34. **Үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр, орлого, зардлыг өмнө нь хүлээн зөвшөөрсөн эрх бүхий этгээд нь УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу энэ Стандартыг буцаах горимоор мөрдөнө.**
35. [Хассан]
- 35А. 2016 оны 4 дүгээр сард гаргасан, *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-ын үр дүнд 13, 32, 33-р параграф болон МЗУ35-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Өмнө нь УСНББОУС 32-ыг мөрдөж байсан байгууллага нь үйлчилгээний концессын хөрөнгийн ангиллыг 13-р параграфын дагуу дахин үнэлнэ. Байгууллага нь уг дахин ангилсан ангилалд хамаарах

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

үйлчилгээний концессын хөрөнгийг УСНББОУС 3-ын дагуу буцаах горимоор толилуулна.

- 35Б. Үйлчилгээний концессын хөрөнгийг 35А параграфын дагуу дахин ангилсан тохиолдолд байгууллага нь уг үйлчилгээний концессын хөрөнгийг дараах байдлаар тайлагнана:
- (а) Үйлчилгээний концессын хөрөнгийг өмнө нь өртгийн загвар ашиглан хэмжсэн ба түүнийг дахин ангилснаар тодорхой нэг хөрөнгүүдийн бүлэгт оруулсан бөгөөд тэрхүү бүлгийг мөн өртгийн загвар ашиглан хэмждэг бол тухайн байгууллага нь өртгийн загварыг үргэлжлүүлэн хэрэглэнэ. Байгууллага нь үйлчилгээний концессын хөрөнгийн өртгийг түүний хуримтлагдсан элэгдэл буюу хорогдуулалт болон аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын хамт дараагийн тайлант үед шилжүүлнэ.
  - (б) Үйлчилгээний концессын хөрөнгийг өмнө нь өртгийн загвар ашиглан хэмжсэн ба түүнийг дахин ангилснаар тодорхой нэг хөрөнгүүдийн бүлэгт оруулсан бөгөөд тэрхүү бүлгийг дахин үнэлгээний загвар ашиглан хэмждэг бол байгууллага нь дараах хоёр хувилбарын аль нэгийг баримтална:
    - (i) Үйлчилгээний концессын хөрөнгийг дахин үнэлэх; эсвэл
    - (ii) Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг авч үздэг УСНББОУС 3-ын шаардлагуудад хамаарахаас бусад тохиолдолд тэрхүү үйлчилгээний концессын хөрөнгийг дахин ангилснаар оруулсан тухайн хөрөнгийн анги дахь үлдсэн бусад хөрөнгүүдэд өртгийн загварыг буцаах горимоор мөрдөнө. Хөрөнгийн өртгийн талаархи мэдээлэл нь бэлэн боломжтой байхгүй тохиолдолд байгууллага нь тэдгээр хөрөнгийн дансны үнийг төсөөлөн тооцсон өртөг байдлаар ашиглаж болно.
  - (в) Үйлчилгээний концессын хөрөнгийг өмнө нь дахин үнэлгээний загвар ашиглан хэмжсэн ба түүнийг дахин ангилснаар тодорхой нэг хөрөнгүүдийн бүлэгт оруулсан бөгөөд тэрхүү бүлгийг өртгийн загвар ашиглан хэмждэг бол байгууллага нь дараах хоёр хувилбарын аль нэгийг баримтална:
    - (i) Үйлчилгээний концессын хөрөнгөнд уг өртгийн загварыг буцаах горимоор мөрдөнө. Хөрөнгийн өртгийн талаархи мэдээлэл нь бэлэн боломжтой байхгүй тохиолдолд байгууллага нь тэдгээр үйлчилгээний концессын хөрөнгийн дансны үнийг төсөөлөн тооцсон өртөг байдлаар ашиглаж болно; эсвэл
    - (ii) Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг авч үздэг УСНББОУС 3-ын шаардлагуудад хамаарахаас бусад тохиолдолд тэрхүү үйлчилгээний концессын хөрөнгийг дахин ангилснаар оруулсан тухайн хөрөнгийн анги дахь үлдсэн бусад хөрөнгүүдийг дахин үнэлнэ.

- (г) Үйлчилгээний концессын хөрөнгийг өмнө нь дахин үнэлгээний загвар ашиглан хэмжсэн ба түүнийг дахин ангилснаар тодорхой нэг хөрөнгүүдийн бүлэгт оруулсан бөгөөд тэрхүү бүлгийг мөн дахин үнэлгээний загвар ашиглан хэмждэг бол тухайн байгууллага нь хөрөнгийн анги нэг бүрийг дахин үнэлгээний нэмэгдлээр тохируулна. Үйлчилгээний концессын хөрөнгийг шилжүүлсэн тухайн анги дахь нэг буюу хэд хэдэн хөрөнгө эсвэл уг үйлчилгээний концессын хөрөнгийн хувьд өмнөх дахин үнэлгээний бууралтыг хүлээн зөвшөөрдөг тохиолдолд байгууллага нь дахин үнэлгээний нэмэгдэл ба хуримтлагдсан ашиг, алдагдлын хооронд шилжүүлэлт хийх шаардлагатай эсэхийг харгалзан үзнэ.

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

36. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2014 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 5, *Зээлийн Өртөг*, УСНББОУС 13, *Түрээс*, УСНББОУС 17, УСНББОУС 29, УСНББОУС 31-ийг мөрдөнө.**
- 36А. **2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 35, 37-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.**
- 36Б. **2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар 13, 32, 33-р параграфууд болон МЗУ35-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**
- 36В. **2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 3, 4-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх**

**тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**

37. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Хавсралт А

### Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 32-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

#### Цар хүрээ (2–7-р параграфыг үзнэ үү)

МЗУ1. Үйлчилгээний концессын хэлцэл дэх хувийн хэвшлийн эзэмшигчид хамаарах нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг тогтоодог Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хорооны Тайлбар 12 (СТОУТХ 12), *Үйлчилгээний Концессын Хэлцэл*-ийн “толин тусгал” байдлаар энэхүү Стандартыг боловсруулсан. Иймээс цар хүрээ, хөрөнгийг хүлээн зөвшөөрөх зарчим, нэр томъёо нь СТОУТХ 12 дахь холбогдох заавар удирдамжтай нийцдэг. Гэвч энэ Стандарт нь эрх бүхий этгээдийн нягтлан бодох бүртгэлийн асуудлуудыг зохицуулдаг учраас СТОУТХ 12-т дурдсан асуудлуудыг эрх бүхий этгээдийн зүгээс дараах байдлаар энэ Стандартад авч үзсэн:

- (а) Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийн (өөрөөр хэлбэл, барьж байгуулсан, хөгжүүлсэн, худалдаж авсан буюу сайжруулсан) бүрдүүлэлтийн хариуд тухайн эзэмшигчид цуврал төлбөр төлөх үүрэг хүлээсэн тохиолдолд санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. СТОУТХ 12-ын 12, 14, 20-р параграфын дагуу энэ Стандартад тусгайлан заасан хэмжилтийн шаардлагуудыг ашигласнаар эзэмшигч нь өөрийн гүйцэтгэсэн барилгын ажил, хөгжүүлэлт, худлалдан авалт, сайжруулалтын хувьд орлогыг хүлээн зөвшөөрнө. Эзэмшигч нь уг үйлчилгээний концессын хэлцлийг байгуулахын өмнө эзэмшиж, үндсэн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрч байсан хөрөнгийг СТОУТХ 12-ын 8-р параграфын дагуу үл хүлээн зөвшөөрнө.
- (б) Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгө буюу орлого бий болгодог бусад хөрөнгийг гуравдагч талын хэрэглэгчдэд ашиглуулснаар орлого олох эрхийг эзэмшигчид олгосон үед өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. СТОУТХ 12-ын 26-р параграфын дагуу эзэмшигч нь биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.
- (в) Эрх бүхий этгээд нь эзэмшиж, ашиглах эрхийг тухайн эзэмшигчид олгосон ба цаашид өөрөө хяналт тавихгүй болсон хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө. СТОУТХ 12-ын 27-р параграфын дагуу эзэмшигч нь ийм хөрөнгө ба уг хөрөнгийн солилцооны хариуд өөрийн хариуцсан аливаа үүргийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

МЗУ2. Ашиглалтын нийт хугацааны хөрөнгөөс бусад, хөрөнгө нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах нөхцлүүдийг Стандартын 9-р параграфт заасан. Ашиглалтын нийт хугацааны хөрөнгө нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах нөхцлүүдийг Стандартын 10-р параграфт тусгайлан заасан.



### **Тодорхойлолт (8-р параграфыг үзнэ үү)**

МЗУ3. Үйлчилгээний концессын хэлцлийг 8-р параграфт тодорхойлсон. Үйлчилгээний концессын хэлцлийн нийтлэг шинжүүд нь:

- (а) Эрх бүхий этгээд нь улсын секторын байгууллага байна;
- (б) Эзэмшигч нь үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох үйлчилгээний удирдлагын наад зах нь зарим асуудлыг хариуцах бөгөөд эрх бүхий этгээдийн нэрийн өмнөөс зөвхөн агентын үүрэг гүйцэтгэхгүй;
- (в) Хэлцэл нь эзэмшигчийн нэхэмжлэх анхны үнийг тогтоох ба уг үйлчилгээний концессын хэлцлийн хугацаан дахь үнийн өөрчлөлтийг зохицуулдаг;
- (г) Аль тал нь анх түүнийг санхүүжүүлсэн эсэхээс үл хамааран эзэмшигч нь хэлцлийн хугацааны эцэст уг үйлчилгээний концессын хөрөнгийг тусгайлан заасан нөхцөл байдалтайгаар нэмэлт төлбөргүйгээр буюу багахан төлбөртэйгээр тухайн эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх үүрэг хүлээдэг;
- (д) Гүйцэтгэлийн стандарт, үнийн тохируулга хийх механизм, маргааныг арбитраар шийдвэрлүүлэх нөхцлийг тогтоосон заавал биелүүлэх хэлцлээр уг үйлчилгээний концессын хэлцлийг зохицуулдаг.

МЗУ4. Үйлчилгээний концессын хөрөнгийг 8-р параграфт тодорхойлсон. Үйлчилгээний концессын хөрөнгийн жишээнд авто зам, гүүр, туннель, шорон, эмнэлэг, нисэх онгоцны буудал, ус түгээх байгууламж, эрчим хүчний хангамжийн болон харилцаа холбооны сүлжээ, цэргийн болон бусад үйл ажиллагаанд зориулсан байгууламж, төрийн үйлчилгээ үзүүлэхийн тулд захиргааны зорилгоор ашиглах бусад эргэлтийн бус биет ба биет бус хөрөнгө хамаарна.

### **Үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба анхны хэмжилт (9–13-р параграфыг үзнэ үү)**

*Үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт*

МЗУ5. Үйлчилгээний концессын хөрөнгийг 9-р параграф (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграф)-ын дагуу хүлээн зөвшөөрөх эсэх үнэлгээг тухайн хэлцлийн бүх баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн хийдэг.

МЗУ6. 9(а) параграфт дурдсан, хяналт буюу зохицуулалт нь заавал биелүүлэх хэлцэл болон бусад байдлаар хэрэгжиж болох (эрх бүхий этгээдтэй нэг ижил салбар буюу секторт үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагуудыг зохицуулдаг гуравдагч талын зохицуулагчаар хэрэгжих гэх мэт) бөгөөд үүнд, эрх бүхий этгээд нь бүх гарц бүтээгдэхүүнийг худалдан авах нөхцөл, түүнчлэн бүх буюу зарим гарц бүтээгдэхүүнийг

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

бусад хэрэглэгч нар худалдан авах нөхцөл хамаардаг. Тухайн хөрөнгийн үр өгөөжид бусад этгээд хандан нэвтрэхийг хязгаарлах буюу зохицуулах чадвар боломж бол үр өгөөжид нь бүх байгууллагууд хандан нэвтэрч, ашиглаж болох олон нийтийн бараанаас тэрхүү байгууллагын хөрөнгийг ялган зааглах хяналтын чухал элемент юм. Заавал биелүүлэх хэлцэл нь эзэмшигчийн нэхэмжлэх анхны үнийг тогтоох ба уг үйлчилгээний концессын хэлцлийн хугацаан дахь үнийн өөрчлөлтийг зохицуулдаг. Заавал биелүүлэх хэлцэл нь үйлчилгээний концессын хөрөнгийн ашиглалтанд хяналт тавих эрхийг эзэмшигчид шилжүүлдэг тохиолдолд тухайн хөрөнгө нь уг эзэмшигч үйлчилгээгээ үзүүлж, хүргэх ёстой тэдгээр талуудтай холбоотой хяналтын талаархи 9(а) параграфт заасан нөхцлийг хангах юм.

- МЗУ7. 9(а) параграфын зорилгын хувьд, эрх бүхий этгээд нь үнийн бүрэн хяналттай байх албагүй юм: үнийг эрх бүхий этгээд, заавал биелүүлэх хэлцэл эсвэл эрх бүхий этгээдтэй нэг ижил салбар буюу секторт үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагуудыг (жишээлбэл; эмнэлэг, сургууль, их дээд сургууль) зохицуулдаг гуравдагч талын зохицуулагчаар (жишээлбэл; дээд үнэ тогтоох механизмаар) зохицуулдаг байхад хангалттай юм. Гэвч тухайн нөхцлийг хэлцлийн мөн чанарын хувьд харгалзан үзнэ. Зөвхөн ховор тохиолдолд хэрэглэх дээд хэмжээ гэх мэт чухал бус шинжүүдийг авч үзэхгүй. Харин эсрэгээр тухайлбал; хэлцэл нь үнэ тогтоох эрхийг эзэмшигчид олгох зорилготой боловч илүү давсан ашгийг эрх бүхий этгээдэд буцаан өгөх бол уг эзэмшигчийн өгөөжийн дээд хязгаарыг тогтоох ба хяналтын сорилын үнийн нөхцөл хангагдах юм.
- МЗУ8. Олон засгийн газар нь эдийн засгийн тодорхой салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын төлөв байдлыг шууд эсвэл тусгайлан байгуулсан агентлагаар дамжуулан зохицуулах бүрэн эрхтэй байдаг. 9(а) параграфын зорилгын хувьд, дээр дурдсан зохицуулалтын ерөнхий бүрэн эрх нь хяналтыг орлон бий болгохгүй. Энэ Стандартад үйлчилгээний концессын хэлцлийн зөвхөн тусгай нөхцөл, болзлын хүрээнд “зохицуулах” гэсэн нэр томъёог мөрдөх зорилготой байдаг. Жишээлбэл; төмөр замын үйлчилгээний зохицуулагч байгууллага нь бүхэлдээ төмөр замын салбарт мөрдөх үнэ тарифыг тогтоож болох юм. Тухайн улсын эрх зүйн хүрээнээс хамааран ийм тариф нь төмөр замын тээврийн нөхцөлтэй холбоотой үйлчилгээний концессын хэлцлийг зохицуулах заавал биелүүлэх хэлцэлд шууд бусаар илэрхийлэгдсэн эсвэл түүнд тусгайлан заагдсан байж болно. Гэвч хоёр тохиолдлын аль алины хувьд үйлчилгээний концессын хөрөнгийн хяналт нь тухайн байгууллага төмөр замын үйлчилгээний зохицуулагчтай холбоотой гэсэн баримт материалд биш, харин гэрээ буюу адилтгах заавал биелүүлэх хэлцэл эсвэл төмөр замын үйлчилгээнд хамаарах тусгай зохицуулалтаас үүдэлтэй байдаг.
- МЗУ9. 9(б) параграфын зорилгын хувьд, аливаа мэдэгдэхүйц үлдэх хувь оролцоонд эрх бүхий этгээдийн тавих хяналт нь тухайн хөрөнгийг худалдан борлуулах буюу барьцаалах ба уг үйлчилгээний концессын хэлцлийн хугацааны туршид хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглах эрхийг эрх

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

бүхий этгээдэд олгох тэрхүү эзэмшигчийн практик чадвар боломжийн аль алиныг хязгаарладаг байвал зохино. Хөрөнгийн үлдэх хувь оролцоо нь үйлчилгээний концессын хугацааны эцэст хүлээгдэж буй насжилт ба нөхцөл байдал дахь тухайн хөрөнгийн тооцоолсон одоогийн үнэ цэнэ байна.

- МЗУ10. Хяналтыг удирдлагаас ялган зааглах хэрэгтэй. Хэрэв эрх бүхий этгээд нь 9(а) параграфт дурдсан, хяналтын зэрэг хэмжээ ба тухайн хөрөнгө дэх аливаа мэдэгдэхүйц үлдэх хувь оролцооны аль алиныг хадгалан үлдсэн бол хэдийгээр эзэмшигч нь олон тохиолдолд удирдлагын өргөн хүрээтэй бүрэн эрхтэй байж болох боловч уг хөрөнгийг эрх бүхий этгээдийн нэрийн өмнөөс зөвхөн удирдан зохицуулж байдаг.
- МЗУ11. Эрх бүхий этгээд нь тухайн хөрөнгийг, үүн дотроо шаардлагатай аливаа орлуулалтыг түүний эдийн засгийн нийт ашиглалтын хугацааны туршид хэзээ хянах эсэхийг 9(а) ба 9(б) параграфт заасан нөхцлүүд хамтдаа тодорхойлдог. Жишээлбэл; эзэмшигч нь тухайн хэлцлийн хугацааны туршид хөрөнгийн тодорхой нэг хэсгийг (жишээлбэл; замын хамгийн дээд давхарга эсвэл барилгын дээврийг) сольж орлуулах ёстой бол уг хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Ингэснээр 9(б) параграфт дурдсан нөхцөл нь бүхэлдээ тухайн хөрөнгийн хувьд, үүн дотроо, хэрэв сольж орлуулагдсан хэсгийн эцсийн орлуулалтан дахь аливаа мэдэгдэхүйц үлдэх хувь оролцоог уг эрх бүхий этгээд хянадаг бол тэрхүү орлуулагдсан хэсгийн хувьд хангагдана.
- МЗУ12. Үйлчилгээний концессын хөрөнгийн ашиглалтыг 9(а) параграфт дурдсан арга маягаар зарим үед хэсэгчлэн зохицуулдаг ба зарим хэсгийг зохицуулдаггүй. Гэхдээ ийм хэлцэл нь янз бүрийн хэлбэртэй байдаг:
- (а) Биет байдлаар салган зааглах ба бие даасан байдлаар ажиллуулж болох бөгөөд УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-д тодорхойлсон мөнгө бий болгогч нэгжийн тодорхойлолтыг хангадаг аливаа хөрөнгийг хэрэв зохицуулалтгүй зорилгоор бүхэлд нь ашиглавал (жишээлбэл; эмнэлгийн барилгын нэг жигүүрийг хувийн компанид ашиглуулах ба эрх бүхий этгээд нь иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхийн тулд барилгын бусад үлдсэн хэсгийг ашиглах) 9(а) параграфт заасан нөхцөл биелэгдэх эсэхийг тодорхойлохын тулд тэдгээрийг тус тусад нь шинжилж үзнэ.
  - (б) Цэвэр туслах шинжтэй үйл ажиллагааг (эмнэлгийн харъяа дэлгүүр гэх мэт) зохицуулдаггүй тохиолдолд тэдгээр туслах үйлчилгээ байгаагүй мэтээр хяналтын сорилыг хийнэ. Яагаад гэвэл, эрх бүхий этгээд нь 9(а) параграфт дурдсан арга маягаар уг үйлчилгээг хянадаг тохиолдолд туслах үйл ажиллагааны оршин байдал нь үйлчилгээний концессын хөрөнгөнд уг эрх бүхий этгээдийн тавих хяналтыг сулруулахгүй.
- МЗУ13. Эзэмшигч нь МЗУ12(а) параграфт тайлбарласан салган зааглаж болох хөрөнгө, эсвэл МЗУ12(б) параграфт дурдсан зохицуулалтгүй туслах

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

үйлчилгээг үзүүлэхэд ашигладаг байгууламжийг ашиглах эрхтэй байж болно. Аль нэг тохиолдолд энэ нь эрх бүхий этгээдээс эзэмшигчид түрээслэх түрээсийн шинж чанартай байж болох; хэрэв тийм бол үүнийг УСНББОУС 13-ын дагуу тайлагнана.

### **Эрх бүхий этгээдийн одоо байгаа хөрөнгө**

- МЗУ14. Хэлцэл нь эрх бүхий этгээдийн одоо байгаа дараах хөрөнгийг хамарсан байж болно:
- (а) Энд эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хэлцлийн зорилгоор хандан нэвтрэх эрхийг эзэмшигчид олгодог; эсвэл
  - (б) Энд эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийн нөхөн олговор байдлаар орлого олохын тулд уг хөрөнгөнд хандан нэвтрэх эрхийг эзэмшигчид олгодог.
- МЗУ15. 11-р параграфын шаардлага нь 9-р параграфын (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфын) дагуу анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрсөн хөрөнгийг хэмжих явдал юм. Үйлчилгээний концессын хэлцэлд ашигласан уг эрх бүхий этгээдийн одоо байгаа хөрөнгийг энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрөх биш, харин дахин ангилна. Эрх бүхий этгээдийн одоо байгаа хөрөнгийн зөвхөн сайжруулалтыг (жишээлбэл; хүчин чадлын нэмэгдэлтийг) 9-р параграфын (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфын) дагуу үйлчилгээний концессын хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө.
- МЗУ16. Хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид нөлөөлөх уг хөрөнгийн ашиглалт өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд УСНББОУС 17 эсвэл УСНББОУС 31-ийн аль тохиромжтойд заасан үнэ цэнийн бууралтын сорилыг хэрэглэхдээ, эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгө ашиглах эрхийг уг эзэмшигчид олголтыг тэрхүү үнэ цэнийн бууралт үүсэхэд хүргэх нөхцөл байдлаар заавал авч үзэх шаардлагагүй юм. Ийм нөхцөл байдлын дагуу үнэ цэнийн бууралтын аливаа шинж тэмдэг илэрсэн эсэхийг тодорхойлохын тулд эрх бүхий этгээд нь УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* ба УСНББОУС 26-гийн аль тохиромжтойг лавлагаа болгоно.
- МЗУ17. Хэрэв хөрөнгө нь 9-р параграфт (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфт) заасан хүлээн зөвшөөрөлтийн нөхцлүүдийг цаашид хангахгүй бол эрх бүхий этгээд нь УСНББОУС 17 эсвэл УСНББОУС 31-ийн аль тохиромжтойд дурдсан үл хүлээн зөвшөөрөлтийн зарчмуудыг баримтална. Жишээлбэл; эзэмшигчид уг хөрөнгийг байнгын нөхцлөөр шилжүүлсэн бол түүнийг үл хүлээн зөвшөөрнө. Хэрэв хөрөнгийг түр хугацаагаар шилжүүлсэн бол тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг тодорхойлохын тулд эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хэлцлийн энэхүү нөхцлийн мөн чанарыг харгалзан үзнэ. Ийм тохиолдолд уг хэлцэл нь УСНББОУС 13-ын дагуу тайлагнавал зохих

түрээсийн ажил гүйлгээ эсвэл борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ эсэхийг эрх бүхий этгээд нь мөн харгалзан үзнэ.

МЗУ18. Үйлчилгээний концессын хэлцэл нь тухайн хөрөнгөөр бүрдүүлэх ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нэмэгдэлт гэх мэт уг эрх бүхий этгээдийн одоо байгаа хөрөнгийн сайжруулалттай холбоотой тохиолдолд энэ нь 9-р параграфт (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфт) заасан хүлээн зөвшөөрөлтийн нөхцлүүдийг хангах эсэхийг тодорхойлохын тулд тэрхүү сайжруулалтыг үнэлнэ. Хэрэв тэдгээр нөхцлүүд хангагдаж байвал сайжруулалтыг энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ.

#### **Эзэмшигчийн одоо байгаа хөрөнгө**

МЗУ19. Эзэмшигч нь өөрөө байж байгуулаагүй, хөгжүүлээгүй, худалдан аваагүй боловч үйлчилгээний концессын хэлцэлд ашиглах зорилгоор хөрөнгийг нийлүүлж болох юм. Үйлчилгээний концессын хэлцэл нь уг үйлчилгээний концессын зорилгоор эзэмшигчийн ашигладаг бөгөөд түүний одоо байгаа хөрөнгөтэй холбоотой бол тухайн хөрөнгө нь 9-р параграфт (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфт) заасан нөхцлүүдийг хангаж буй эсэхийг эрх бүхий этгээд нь тодорхойлно. Хэрэв хүлээн зөвшөөрөлтийн нөхцлүүд хангагдаж байвал эрх бүхий этгээд нь уг хөрөнгийг үйлчилгээний концессын хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх ба түүнийг энэ Стандартын дагуу тайлагнана.

#### **Барьж байгуулсан эсвэл хөгжүүлсэн хөрөнгө**

МЗУ20. Хэрэв барьж байгуулсан эсвэл хөгжүүлсэн хөрөнгө нь 9-р параграфт (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфт) заасан нөхцлүүдийг хангаж байвал эрх бүхий этгээд нь уг хөрөнгийг энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ. Үйлчилгээний концессын хөрөнгийг хэзээ хүлээн зөвшөөрөх шалгуурыг УСНББОУС 17 ба УСНББОУС 31-ийн аль тохиромжтой Стандартаар тогтоодог. УСНББОУС17 ба УСНББОУС 31-гийн аль аль нь зөвхөн дараах тохиолдолд хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг:

- (а) Тухайн зүйлтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь уг байгууллагад орох нилээд магадлалтай байх;
- (б) Тухайн зүйлийн өртөг буюу бодит үнэ цэнийг найдвартай<sup>2</sup> хэмжиж чадах.

МЗУ21. Хөрөнгийг барьж байгуулах буюу хөгжүүлэх хугацаанд үйлчилгээний концессын хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо эдгээр

---

<sup>2</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

шалгуурыг уг заавал биелүүлэх хэлцлийн тусгай нөхцөл, болзлын хамт харгалзан үзэх шаардлагатай. Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн аль алины хувьд, барьж байгуулах буюу хөгжүүлэх хугацаанд уг хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдаж болох бөгөөд хэрэв хангагдаж байвал эрх бүхий этгээд нь тэрхүү хугацаанд ихэвчлэн үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

МЗУ22. Хүлээн зөвшөөрөлтийн эхний шалгуур нь тухайн эрх бүхий этгээдэд эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орохыг шаарддаг. Эрх бүхий этгээдийн зүгээс авч үзвэл, үйлчилгээний концессын хөрөнгийн нэн тэргүүний зорилго нь улсын секторын эрх бүхий этгээдийн нэрийн өмнөөс үйлчилгээний чадавхийг бүрдүүлэх явдал юм. Үйлчилгээний концессын хөрөнгийн үйлчилгээний чадавхи нь тухайн хугацаанд эрх бүхий этгээдэд орох эсэхийг тодорхойлохын тулд барьж байгуулалтын буюу хөгжүүлэлтийн өртөг зардал гарах хугацаа, заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүдийг уг эрх бүхий этгээд нь өөрөө ашиглах зорилгоор барьж байгуулдаг буюу хөгжүүлдэг хөрөнгөтэй ижил төсөөтэй байдлаар үнэлнэ.

МЗУ23. Хүлээн зөвшөөрөлтийн хоёр дахь шалгуур нь хөрөнгийн анхны өртөг буюу бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахаар байхыг шаарддаг. Иймээс УСНББОУС 17 эсвэл УСНББОУС 31-ийн аль тохиромжтойд заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахын тулд эрх бүхий этгээд нь барьж байгуулалтын эсвэл хөгжүүлэлтийн хугацааны туршид тухайн хөрөнгийн өртөг буюу бодит үнэ цэнийн талаархи найдвартай мэдээлэлтэй байх ёстой. Жишээлбэл; үйлчилгээний концессын хэлцэл нь хөрөнгийн барьж байгуулалт буюу хөгжүүлэлтийн хугацаанд эрх бүхий этгээдэд явцын тайлан гаргаж өгөхийг эзэмшигчээс шаарддаг бол гарсан өртөг зардлыг хэмжиж болох ба ингэснээр барьж байгуулсан хөрөнгийн хувьд УСНББОУС 17-д, харин хөгжүүлсэн хөрөнгийн хувьд УСНББОУС 31-д заасан хүлээн зөвшөөрөлтийн зарчмыг хангаж болох юм. Түүнчлэн, гэрээний буюу адилтгах заавал биелүүлэх хэлцлийн тусгай нөхцлүүдийг хангахын тулд эрх бүхий этгээд нь барьж байгуулсан болон хөгжүүлсэн хөрөнгийг хүлээн авахаас зайлсхийх чадвар боломж багатай бол явц өрнөл байдлаар хүлээн зөвшөөрсөн өртөг зардал нь тухайн хөрөнгийн иж бүрдэлд зориулагдан гарсан байна. Иймээс эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

### *Үйлчилгээний концессын хөрөнгийн хэмжилт*

МЗУ24. 11-р параграф нь 9-р параграфын (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфын) дагуу хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний концессын хөрөнгийг анх бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг. Тухайлбал; барьж байгуулсан буюу хөгжүүлсэн үйлчилгээний концессын хөрөнгийн өртөг болон одоо байгаа хөрөнгийн аливаа сайжруулалтын өртгийг анх хүлээн зөвшөөрөлтийн үед тодорхойлохдоо бодит үнэ цэнийг ашигладаг. Энэ Стандартын 12-р параграфын дагуу үйлчилгээний концессын хөрөнгө гэж дахин ангилсан, уг эрх бүхий

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

этгээдийн одоо байгаа хөрөнгөнд 11-р параграфын шаардлагыг мөрдөхгүй. Анх хүлээн зөвшөөрөлтийн үед бодит үнэ цэнийг ашиглах нь УСНББОУС 17 эсвэл УСНББОУС 31-д заасан дахин үнэлгээг орлохгүй юм.

МЗУ25. Эрх бүхий этгээд ба эзэмшигчийн хооронд солилцсон төлбөрийн төрөл нь анх хүлээн зөвшөөрөлтийн үед уг үйлчилгээний концессын хөрөнгийн бодит үнэ цэнийг хэрхэн тодорхойлоход нөлөө үзүүлдэг. Дараах параграфууд нь солилцсон төлбөрийн төрөлд үндэслэн тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хэрхэн тодорхойлохыг тайлбарласан:

- (а) Эрх бүхий этгээд нь эзэмшигчид төлбөр төлсөн тохиолдолд тухайн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ нь уг хөрөнгийн хувьд эзэмшигчид төлсөн төлбөрийн нэг хэсгийг илэрхийлнэ.
- (б) Эрх бүхий этгээд нь тухайн хөрөнгийн хувьд эзэмшигчид төлбөр төлдөггүй тохиолдолд уг хөрөнгийг УСНББОУС 17 ба УСНББОУС 31-д заасан мөнгөн бус хөрөнгийн солилцоотой ижил арга замаар тайлагнана.

### **Нөхөн төлбөрийн төрөл**

МЗУ26. Үйлчилгээний концессын хэлцэл нь ижил байлаа гэхэд ховор тохиолдол юм; техникийн шаардлагууд нь сектор ба улс орон бүрд өөр өөр байдаг. Түүнчлэн, хэлцлийн нөхцөл нь тухайн улсын ерөнхий эрх зүйн хүрээний тусгай шинж чанаруудаас бас хамаарч болох юм. Хэрэв байдаг бол гэрээний хууль нь тухайн тодорхой гэрээнүүдэд дахин давтан тусгах шаардлагагүй нөхцлүүдийг агуулсан байж болно.

МЗУ27. Үйлчилгээний концессын хэлцлийн нөхцлөөс хамааран эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгө болон үзүүлсэн үйлчилгээний хариуд дараах зүйлсийг дурын хэлбэрээр хослуулан эзэмшигчид олгож болно:

- (а) Эзэмшигчид төлбөр төлөх (жишээлбэл; мөнгө);
- (б) Доорх гэх мэт бусад арга хэрэгслээр эзэмшигчид нөхөн төлбөр олгох:
  - (i) Үйлчилгээний концессын хөрөнгийг гуравдагч талын хэрэглэгчид ашиглуулснаар орлого олох эрхийг уг эзэмшигчид олгох; эсвэл
  - (ii) Орлого бий болгох өөр бусад хөрөнгийг тухайн эзэмшигч ашиглах эрхийг түүнд олгох.

МЗУ28. Эрх бүхий этгээд нь эзэмшигчид төлбөр төлснөөр уг үйлчилгээний концессын хөрөнгийн хувьд эзэмшигчид нөхөн төлбөр олгосон тохиолдолд тэдгээр төлбөрийн хөрөнгийн болон үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгүүдийг салган зааглах боломжтой (жишээлбэл; үйлчилгээний концессын хөрөнгөнд хуваарилагдах тэдгээр урьдчилан

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

тодорхойлсон цуврал төлбөрүүдийн дүнг тухайн заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заасан байдаг) эсвэл салган зааглах боломжгүй байж болно.

### **Салган зааглах боломжтой төлбөрүүд**

МЗУ29. Үйлчилгээний концессын хэлцлийг янз бүрийн нөхцөл байдалд салган зааглаж болох бөгөөд үүнд дараах нөхцлүүд хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Төлбөрийн гүйлгээний тухайн үйлчилгээний концессын хөрөнгийн бэлэн боломжтой байдлаас хамааран хувьсан өөрчлөгддөг хэсэг ба тодорхой үйлчилгээний ашиглалт буюу гүйцэтгэлээс хамааран хувьсан өөрчлөгддөг хэсгийг ялган тодорхойлог;
- (б) Үйлчилгээний концессын хэлцлийн янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүд нь өөр өөр тайлант үеүдэд хийгдэх буюу тэдгээрийг тус тусад нь дуусгавар болгох боломжтой байх. Жишээлбэл; хэлцлийн бусад үлдсэн хэсгүүдийн цаашдын хэвийн үргэлжлэлд нөлөө үзүүлэхгүйгээр бие даасан үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийг дуусгавар болгох боломжтой байх; эсвэл
- (в) Үйлчилгээний концессын хэлцлийн өөр өөр бүрэлдэхүүн хэсгүүдийг тус тусад нь дахин хэлэлцэн тохиролцож болохоор байх. Жишээлбэл; үйлчилгээний бүрэлдэхүүний хэсгийг зах зээлд үндэслэн тогтоох бөгөөд тухайн үйлчилгээнд тусгайлан хамаарах байдлаар уг эрх бүхий этгээдийн төлсөн төлбөрийн хэсгийг тодорхойлох боломжтой байдлаар тэдгээр өртөг зардлын бүх эсвэл зарим нэмэгдэлт болон бууралтыг эрх бүхий этгээдэд хариуцуулах.

МЗУ30. УСНББОУС 17 ба УСНББОУС 31 нь солилцооны ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг тухайн хөрөнгийн мөнгөн үнэтэй адилтгах дүн болох өртгөөр анх хэмжихийг шаарддаг. Солилцооны ажил гүйлгээний хувьд, өөрөөр зааснаас бусад тохиолдолд тухайн ажил гүйлгээний үнийг түүний бодит үнэ цэнэ гэж үзнэ. Төлбөрийн хөрөнгийн болон үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгүүдийг салган зааглах боломжтой тохиолдолд уг үйлчилгээний концессын хөрөнгийн мөнгөн үнэтэй адилтгах дүн нь тэдгээр төлбөрүүдийн үйлчилгээний концессын хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийн өнөөгийн үнэ цэнэ байна. Гэвч төлбөрүүдийн хөрөнгийн хэсгийн өнөөгийн үнэ цэнэ нь бодит үнэ цэнээс их байвал уг үйлчилгээний концессын хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр анх хэмжинэ.

### **Салган зааглах боломжгүй төлбөрүүд**

МЗУ31. Эрх бүхий этгээдээс эзэмшигчид олгодог төлбөрүүдийн хөрөнгийн болон үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийг салган зааглах боломжгүй бол 11-р параграфт дурдсан бодит үнэ цэнийг тооцооллын арга зүй ашигласнаар тодорхойлно.

МЗУ32. Энэ Стандартын шаардлагуудыг мөрдөх зорилгын хувьд, хэлцлийн дагуу төлөх мөнгөн төлбөрүүд болон бусад төлбөрүүдийг уг хэлцлийн эхэнд



## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

эсвэл хэлцлийн дахин үнэлэлтийн өдөр үйлчилгээний концессын хөрөнгүүдэд болон үйлчилгээний концессын хэлцлийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдэд (жишээлбэл; засвар үйлчилгээ болон үндсэн үйл ажиллагааны үйлчилгээнд) тэдгээрийн харгалзах бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна. Үйлчилгээний концессын хөрөнгийн бодит үнэ цэнэд зөвхөн тухайн хөрөнгөтэй холбоотой дүнгүүдийг хамруулах бөгөөд уг үйлчилгээний концессын хэлцлийн бусад бүрэлдэхүүн хэсгийн дүнг оруулахгүй. Зарим тохиолдолд үйлчилгээний концессын хэлцлийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдэд хамаарах төлбөрүүдээс тухайн хөрөнгийн төлбөрүүдэд хуваарилах хуваарилалт нь тооцооллын арга зүй ашиглахыг уг эрх бүхий этгээдээс шаарддаг. Жишээлбэл; эрх бүхий этгээд нь өөр бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулаагүй тухайн хэлцлийн харьцуулах боломжтой хөрөнгийн бодит үнэ цэнийг лавлага болгосноор, эсвэл харьцуулах боломжтой хэлцлийг лавлагаа болгосноор уг үйлчилгээний концессын хэлцлийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн төлбөрийг тооцоолж, дараа нь тэдгээр төлбөрийг тэрхүү хэлцлийн нийт төлбөрөөс хассанаар тухайн хөрөнгөтэй холбоотой төлбөрүүдийг тооцоолж болно.

### **Эзэмшигч нь нөхөн төлбөрийг өөр хэлбэрээр хүлээн авах**

МЗУ33. 17(б) параграфт дурдсан, ажил гүйлгээний төрлүүд нь мөнгөн бус солилцооны ажил гүйлгээ юм. УСНББОУС 17-гийн 38-р параграф ба УСНББОУС 31-ийн 44-р параграфын аль тохиромжтой заалт нь эдгээр нөхцөл байдлын талаархи заавар удирдамжаар хангана.

МЗУ34. Эзэмшигч нь үйлчилгээний концессын хөрөнгө буюу орлого бий болгодог бусад хөрөнгийг гуравдагч талын хэрэглэгчдэд ашиглуулснаар орлого олох эрхтэй болдог эсвэл эрх бүхий этгээдээс мөнгөн бус төлбөр хүлээн авдаг тохиолдолд уг эрх бүхий этгээд нь тухайн үйлчилгээний концессын хөрөнгийн олж эзэмшилтийн хувьд өртөг зардал шууд гаргадаггүй. Эзэмшигчид олгож буй нөхөн төлбөрийн эдгээр хэлбэрүүд нь үйлчилгээний концессын хөрөнгийн өртөг ба үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд түүнийг ажиллуулсны төлөө тухайн эзэмшигчид нөхөн төлбөр олгоход чиглэгдэнэ. Иймээс эрх бүхий этгээд нь уг хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийг 11-р параграфт нийцсэн арга маягаар анх хэмжих шаардлагатай байдаг.

### *Дараагийн тайлант үеүдийн хэмжилт*

МЗУ35. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийн дараагийн тайлант үеийн хэмжилт болон үл хүлээн зөвшөөрөлтийн хувьд УСНББОУС 17 ба УСНББОУС 31-ийг мөрдөнө. Үйлчилгээний концессын хөрөнгийн үнэ цэнэ буурсан ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг харгалзан үзэхдээ мөн УСНББОУС 21 ба УСНББОУС 26-г мөрдөнө. Энэ Стандартын дагуу үйлчилгээний концессын хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн буюу ангилсан бүх хөрөнгийн хувьд эдгээр Стандартуудын шаардлагыг мөрдөнө.

**Өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт (14–28-р параграфыг үзнэ үү)**

МЗУ36. Үйлчилгээний концессын хөрөнгийг 9-р параграфын (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфын) дагуу хүлээн зөвшөөрсөн зөвхөн тийм тохиолдолд эрх бүхий этгээд нь өр төлбөрийг 14-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө. 14-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн шинж төрөл нь МЗУ25-р параграфт тодорхойлсон нөхцөл байдал нэг бүрд өөрийн мөн чанарын хувьд ялгаатай байдаг.

*Санхүүгийн өр төлбөрийн загвар (18–23-р параграфыг үзнэ үү)*

МЗУ37. Эрх бүхий этгээд нь урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийг тухайн эзэмшигчид төлөх нөхцөлт бус үүрэгтэй тохиолдолд уг өр төлбөр нь УСНББОУС 29-д тодорхойлсон санхүүгийн өр төлбөр гэж үзнэ. Эзэмшигчтэй байгуулсан заавал биелүүлэх хэлцэл нь хуулийн дагуу хүчин төгөлдөр хэрэгжих учраас эрх бүхий этгээд нь тэрхүү үүргээс нэг талын санаачлагаар зайлсхийх ямар нэг боломжтой байлаа гэхэд ийм боломж ихэвчлэн бага байх тул нөхцөлт бус үүргийг хүлээдэг.

МЗУ38. Эрх бүхий этгээд нь концессын хөрөнгө болон үзүүлсэн үйлчилгээний өртгийн хувьд уг эзэмшигчид нөхөн төлбөрийг урьдчилан тодорхойлсон цуврал төлбөр хэлбэрээр олгодог тохиолдолд тэрхүү хөрөнгөтэй холбоотой урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрийн хэсгийг илэрхийлэх дүнг 14-р параграфын дагуу өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө. 21-р параграфт заасан тэдгээр төлбөрүүдийн санхүүгийн зардал ба үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг нь энэхүү өр төлбөрт хамаарахгүй.

МЗУ39. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө эзэмшигчид төлсөн аливаа төлбөрийг урьдчилж төлсөн төлбөр гэж тайлагнана.

МЗУ40. Үйлчилгээний концессын хөрөнгөтэй холбоотойгоор уг эзэмшигчийн капиталын өртгийг тодорхойлох практик боломжтой бол 21-р параграфт дурдсан санхүүгийн зардлыг тэрхүү капиталын өртөгт үндэслэн тодорхойлно.

МЗУ41. Үйлчилгээний концессын хөрөнгөтэй холбоотойгоор уг эзэмшигчийн капиталын өртгийг тодорхойлох практик боломжгүй бол тухайн үйлчилгээний концессын хөрөнгөнд тусгайлан хамаарах хэлцлийн нуугдмал хүүний түвшин, эрх бүхий этгээдийн зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшин буюу тэрхүү хэлцлийн нөхцөл, болзолд тохирох бусад хүүний түвшинг ашиглана.

МЗУ42. Хангалттай мэдээлэл бэлэн байхгүй тохиолдолд ижил төсөөтэй хөрөнгийн олж эзэмшилтийн (жишээлбэл; нэг ижил байршид байгаа ба ижил төсөөтэй нөхцөл бүхий адилтгах хөрөнгийн түрээсийн) хувьд

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

хүлээгдэж буй хүүний түвшинг лавлагаа болгосноор санхүүгийн зардлыг тодорхойлоход ашигласан хүүний түвшинг тооцоолж болно. Бүх дүнгүүд нь ул үндэслэлтэй ба харилцан уялдаатай гэдгийг ханган магадлахын тулд уг хүүний түвшний тооцооллыг дараах зүйлсийн хамтаар нягталж шалгах хэрэгтэй:

- (а) Төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ;
- (б) Тухайн хөрөнгийн төсөөлсөн бодит үнэ цэнэ; ба
- (в) Төсөөлсөн үлдэх үнэ цэнэ.

МЗУ43. Эрх бүхий этгээд нь санхүүжилтэнд оролцдог (жишээлбэл; үйлчилгээний концессын хөрөнгийг барьж байгуулах, хөгжүүлэх, худалдаж авах, сайжруулахад зориулан уг эзэмшигчид зээл олгох буюу санхүүгийн баталгаа гаргах) тохиолдолд санхүүгийн зардлыг тодорхойлохдоо уг эрх бүхий этгээдийн зээлийн өсөн нэмэгдсэн хүүний түвшинг ашиглах нь тохиромжтой байж болно.

МЗУ44. Хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэг эсвэл тухайн хэлцлийг бүхэлд нь дахин хэлэлцэн тохирсноос бусад тохиолдолд санхүүгийн зардлыг тодорхойлоход ашигласан хүүний түвшинг дараагийн тайлант үеүдэд өөрчлөхгүй байж болно.

МЗУ45. Үйлчилгээний концессын хэлцлийн өр төлбөртэй холбоотой санхүүгийн зардлыг УСНББОУС 28, УСНББОУС 29, УСНББОУС 30-ын дагуу бусад санхүүгийн зардалтай нийцсэн байдлаар толилуулна.

МЗУ46. 21-р параграфын дагуу тодорхойлсон, төлбөрүүдийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсгийг тухайн үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд ихэвчлэн жигд хүлээн зөвшөөрдөг. Яагаад гэвэл, хүлээн зөвшөөрөлтийн ийм хэв загвар нь үзүүлсэн үйлчилгээтэй хамгийн сайн нийцэн уялддаг. Тодорхой зардлуудыг тусад нь нөхөн олгох шаардлагатай бөгөөд ийм зарлагын хугацаа мэдэгдэж байх тохиолдолд тэдгээр зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрнө.

### *Эзэмшигчид эрх олгох загвар (24-26-р параграфыг үзнэ үү)*

МЗУ47. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийг гуравдагч талын хэрэглэгчдэд ашиглуулснаар орлого олох эрхийг эзэмшигчид олгосноор тухайн үйлчилгээний концессын хөрөнгө болон үзүүлсэн үйлчилгээний хариуд эзэмшигчид нөхөн төлбөр олгодог тохиолдолд эзэмшигч нь үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд орлого олох эрхтэй болдог. Үүнтэй адилаар, эрх бүхий этгээд нь уг эрхийг үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд эзэмшигчид олгосны хариуд тэрхүү үйлчилгээний концессын хэлцлээр хүлээн авсан хөрөнгөтэй холбоотой өгөөжийг хүртдэг. Ингэхдээ орлогыг нэн даруй хүлээн зөвшөөрдөггүй. Харин хараахан хэрэгжээгүй байгаа орлогын аливаа хэсгийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үйлчилгээний концессын хөрөнгөнд хандан нэвтрэх эрхийг уг үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд эзэмшигчид олгосноор ихэвчлэн тухайн үйлчилгээний концессын хэлцлийн эдийн

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

засгийн мөн чанарт үндэслэн 25-р параграфын дагуу орлогыг хүлээн зөвшөөрөх ба өр төлбөрийг бууруулна. МЗУ27-р параграфт заасанчлан, эрх бүхий этгээд нь гуравдагч талын хэрэглэгчдээс орлогыг шууд олох эрхийн олголт ба мөнгөн төлбөрийг хослуулан өгснөөр уг эзэмшигчид нөхөн төлбөрийг төлж болох юм. Энэ тохиолдолд хэрэв гуравдагч талын хэрэглэгчдээс орлого олох уг эзэмшигчийн эрх нь түүнд эрх бүхий этгээдээс төлөх урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийг мэдэгдэхүйц бууруулах буюу дуусгадаг бол тэрхүү өр төлбөрийн бууруулалтын хувьд өөр суурь (жишээлбэл; эрх бүхий этгээдийн урьдчилан тодорхойлсон ирээдүйн цуврал төлбөрүүдийг бууруулах буюу дуусгах хугацаа) илүү тохиромжтой байж болно.

МЗУ48. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгөөс өөр бусад, орлого бий болгогч хөрөнгийг өгөх замаар тухайн үйлчилгээний концессын хөрөнгө болон үйлчилгээний хариуд уг эзэмшигчид нөхөн төлбөр олгодог тохиолдолд 24-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн орлого ба хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг МЗУ47-р параграфт тодорхойлсонтой ижил арга замаар бууруулна. Энэ тохиолдолд эрх бүхий этгээд УСНББОУС 17 ба УСНББОУС 31-ийн аль тохиромжтой Стандартад заасан үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг бас харгалзан үзнэ.

МЗУ49. Эзэмшигчид эрх олгох загварын дагуу зарим тохиолдолд “сүүдрийн төлбөр”-тэй байж болно. Эзэмшигчийн гүйцэтгэсэн үйлчилгээний концессын хөрөнгийн барьж байгуулалт, хөгжүүлэлт, худалдан авалт, сайжруулалт болон үйл ажиллагааны хариуд зарим сүүдрийн төлбөрийг төлдөг. Эрх бүхий этгээд нь зөвхөн гуравдагч талын хэрэглэгчдэд үйлчилгээний концессын хөрөнгийг ашиглуулсаны төлөө тухайн эзэмшигчид төлбөр төлдөг тохиолдолд энэ төлбөр нь үйлчилгээний концессын хөрөнгийн олж эзэмшилт бус, харин түүний ашиглалтын төлөөх солилцооны нөхөн төлбөр байна. Иймээс эдгээр төлбөрүүд нь МЗУ48-р параграфт заасан өр төлбөртэй холбоогүй байдаг. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийн зөвхөн ашиглалтын хэмжээгээр уг эзэмшигчид нөхөн төлбөр олгох бөгөөд тэрхүү төлбөрийг УСНББОУС 1-ийн дагуу зардал гэж тайлагнана.

### *Хэлцлийг хуваах (27-28-р параграфыг үзнэ үү)*

МЗУ50. Үйлчилгээний концессын хөрөнгийн хувьд эзэмшигч нь нөхөн төлбөрийн зарим хэсгийг урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдээр, харин зарим хэсгийг тухайн үйлчилгээний концессын хөрөнгө буюу орлого бий болгодог өөр бусад хөрөнгийг гуравдагч талд ашиглуулснаар орлого олох эрх байдлаар хүлээн авдаг бол тэрхүү эрх бүхий этгээдийн нөхөн төлбөртэй холбоотой өр төлбөрийн хэсэг нэг бүрийг тусад нь тайлагнах шаардлагатай юм. Энэ тохиолдолд эзэмшигчид олгох нөхөн төлбөрийг тэдгээр урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийн хувьд санхүүгийн өр төлбөрийн хэсэг гэж, харин үйлчилгээний концессын хөрөнгө буюу орлого бий болгох бусад хөрөнгийг гуравдагч талд ашиглуулснаар орлого олох уг эзэмшигчид олгосон эрхийн хувьд өр төлбөрийн хэсэг гэж

хуваана. Өр төлбөрийн хэсэг нэг бүрийг төлсөн буюу төлөх нөхөн төлбөрийн бодит үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрнө.

**Бусад өр төлбөр, үүрэг амлалт, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө (29-р параграфыг үзнэ үү)**

- МЗУ51. Үйлчилгээний концессын хэлцэл нь янз бүрийн санхүүгийн баталгаа (жишээлбэл; үйлчилгээний концессын хөрөнгийн барьж байгуулалт, хөгжүүлэлт, худалдан авалт, сайжруулалтын ажлыг санхүүжүүлэхийн тулд эзэмшигчийн гаргасан өртэй холбоотой зээлийн баталгаа, барьцаа буюу алдагдал нөхөх баталгаа) эсвэл гүйцэтгэлийн баталгааг (жишээлбэл; орлогын хамгийн бага гүйлгээний баталгаа, үүн дотроо дутуу дүнгийн нөхөн төлбөрийг) агуулсан байж болно.
- МЗУ52. Эрх бүхий этгээдийн гаргасан зарим баталгаа нь санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолтыг хангаж болох юм. Үйлчилгээний концессын хэлцлийн нэг хэсэг байдлаар эрх бүхий этгээдийн гаргасан баталгаа нь санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолтыг хангах эсэхийг тухайн эрх бүхий этгээд нь тодорхойлох ба уг баталгааны тайлагналын хувьд УСНББОУС 28, УСНББОУС 29, УСНББОУС 30-ийг мөрдөнө. Баталгаа нь даатгалын гэрээ байх тохиолдолд эрх бүхий этгээд нь даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх сонголт хийж болно. Цаашдын заавар удирдамжийн хувьд УСНББОУС 28-ын МЗУ3-МЗУ9-р параграфыг үзнэ үү.
- МЗУ53. Санхүүгийн баталгааны гэрээтэй холбоотой УСНББОУС 28 ба УСНББОУС 29-ийн шаардлагуудыг хангадаггүй буюу даатгалын гэрээ биш, тийм баталгаа болон үүрэг амлалтыг УСНББОУС 19-ийн дагуу тайлагнана.
- МЗУ54. Үйлчилгээний концессын хэлцлийн нөхцлийн талаархи маргааны улмаас болзошгүй хөрөнгө эсвэл болзошгүй өр төлбөр үүсэж болно. Ийм болзошгүй зүйлсийг УСНББОУС 19-ийн дагуу тайлагнана.

**Бусад орлого (30-р параграфыг үзнэ үү)**

- МЗУ55. Үйлчилгээний концессын хөрөнгөнд хандан нэвтрэх эрхийн хариуд эзэмшигч нь урьдчилан тодорхойлсон нөөцийн цуврал орлогын гүйлгээгээр эрх бүхий этгээдийг хангаснаар түүнд нөхөн төлбөр олгож болно. Үүнд дараах зүйлс хамаарна:
- (а) Урьдчилгаа төлбөр эсвэл төлбөрүүдийн гүйлгээ;
  - (б) Орлого хуваалцах нөхцөл;
  - (в) Эрх бүхий этгээдээс эзэмшигчид төлөх урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийн бууруулалт;
  - (г) Орлого бий болгох хөрөнгийг тухайн эзэмшигчид ашиглуулсаны түрээсийн төлбөр.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

- МЗУ56. Эзэмшигч нь үйлчилгээний концессын хэлцлийн хугацааны туршид уг үйлчилгээний концессын хөрөнгийг ашиглах эрхийн төлөө эрх бүхий этгээдэд урьдчилгаа төлбөр, төлбөрүүдийн гүйлгээ буюу бусад төлбөрийг төлдөг бол эрх бүхий этгээд нь тэдгээр төлбөрүүдийг УСНББОУС 9-ийн дагуу тайлагнана. Үйлчилгээний концессын хөрөнгөнд хандан нэвтрэх эрхийг эзэмшигчид олгох уг эрх бүхий этгээдийн үүргийг тусгайлан заасан тухайн үйлчилгээний концессын хэлцлийн нөхцөл ба болзлуудаар орлогын хүлээн зөвшөөрөлтийн хугацааг тодорхойлдог.
- МЗУ57. Үйлчилгээний концессын хөрөнгө эсвэл орлого бий болгодог бусад хөрөнгийг гуравдагч талд ашиглуулснаар орлого олох эрхийн хариуд эзэмшигч нь үйлчилгээний концессын хөрөнгөөс гадна урьдчилгаа төлбөр, төлбөрүүдийн гүйлгээ буюу бусад төлбөрийг тэрхүү эрх бүхий этгээдэд төлдөг тохиолдолд эзэмшигчээс хүлээн авсан ба тухайн тайлант үед хэрэгжээгүй төлбөрийн аливаа хэсгийг уг орлогын хүлээн зөвшөөрөлтийн нөхцлүүд биелэгдэх хүртэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- МЗУ58. Орлогын хүлээн зөвшөөрөлтийн нөхцлүүд биелэгдсэн тохиолдолд 30-р параграфын дагуу орлогыг хүлээн зөвшөөрөхийн хэрээр өр төлбөрийг бууруулна.
- МЗУ59. Гэвч үйлчилгээний концессын хэлцэлд ашиглаж болох төрөл бүрийн хөрөнгүүдийн ялгаатай шинж чанар ба хэлцлийн үйлчлэх хугацаа олон жил байдгийг харгалзан үзвэл тухайн заавал биелүүлэх хэлцэлд заасан мөнгөн орлогын гүйлгээтэй холбоотойгоор орлогыг хүлээн зөвшөөрөх илүү тохиромжтой хувилбар аргууд байж болох юм. Ийм арга нь үйлчилгээний концессын хөрөнгөнд хандан нэвтрэх уг эзэмшигчийн эрхийн эдийн засгийн ашиглалт ба/буюу мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг илүү сайн тусган илэрхийлнэ. Жишээлбэл; нэрлэсэн суурьтай харьцуулахад дискаунтчилсан сууриар орлогыг илүү жигд хүлээн зөвшөөрдөг нийлмэл хүүний хүчин зүйлд хэрэглэгдэх аннюту арга нь хэдэн арван жилийн хугацаатай үйлчилгээний концессын хэлцлийн хувьд илүү тохиромжтой байж болно.
- МЗУ60. Эзэмшигчээс урьдчилгаа төлбөр хүлээн авдаг тохиолдолд үйлчилгээний концессын хөрөнгөнд хандан нэвтрэх уг эзэмшигчийн эрхийн эдийн засгийн ашиглалт ба/буюу мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг илүү сайн тусган илэрхийлэх тийм арга замаар орлогыг хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд жил бүр хэсэгчилсэн төлбөр эсвэл тодорхой жилүүдийн хувьд урьдчилан тодорхойлсон нийт дүнг төлөхийг эзэмшигчээс шаарддаг тохиолдолд орлогыг уг тусгайлан заасан хугацааны туршид хүлээн зөвшөөрнө.
- МЗУ61. Үйлчилгээний концессын хөрөнгийг гуравдагч талд ашиглуулснаар орлого олох эрхийг эзэмшигчид олгодог үйлчилгээний концессын хэлцлийн хувьд, орлого нь тухайн үйлчилгээг үзүүлэхийн хэрээр хүлээн авах эдийн засгийн үр өгөөжийн орлогын гүйлгээтэй холбоотой байх бөгөөд иймээс өр төлбөрийн бууралттай ижил сууриар орлогыг хүлээн

зөвшөөрнө. Ийм тохиолдолд эрх бүхий этгээд нь тухайн эзэмшигчтэй байгуулах хэлцэлд орлого хуваалцах нөхцлийг тусгахын тулд түүнтэй ямагт хэлэлцэн тохиролцоно. Үйлчилгээний концессын хэлцлийн нэг хэсэг байдлаар хуваалцах орлого нь эзэмшигчийн олсон бүх орлогод, эсвэл тодорхой босго шалгуураас давсан орлогод, эсвэл өгөөжийн тогтоосон түвшинд хүрэхэд тухайн эзэмшигчид шаардлагатай хэмжээнээс хэтэрсэн орлогод үндэслэж болно.

- МЗУ62. Үйлчилгээний концессын хэлцэлд заасан орлого хуваалцах нөхцлөөс бий болсон орлогыг тухайн эрх бүхий этгээд нь аливаа болзошгүй үйл явдал гарч тохиолдсон (жишээлбэл; орлогын босго шалгуурт хүрсэн) гэж төсөөлсөний дараах уг холбогдох хэлцлийн мөн чанарын дагуу орлого хэрэгжихийн хэрээр хүлээн зөвшөөрнө. Болзошгүй үйл явдал хэзээ гарч тохиолдсон гэдгийг тодорхойлохын тулд эрх бүхий этгээд нь УСНББОУС 19-ийг дагаж мөрдөнө.
- МЗУ63. Эзэмшигчид төлөхийг эрх бүхий этгээдээс шаардах байсан ирээдүйн урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийн бууралт нь тухайн эрх бүхий этгээдэд мөнгөн бус урьдчилгаа төлбөр олгохтой адил юм. Уг өр төлбөр буурахын хэрээр ийм орлогыг хүлээн зөвшөөрнө.
- МЗУ64. Орлого бий болгодог хөрөнгөнд хандан нэвтэрсэний төлөө эзэмшигч нь нэрлэсэн түрээсийн төлбөр төлдөг тохиолдолд ингэж хүлээн авсан түрээсийн орлогыг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)-ийн* дагуу хүлээн зөвшөөрнө.

### **Толилуулга ба тодруулга (31–33-р параграфыг үзнэ үү)**

- МЗУ65. Үйлчилгээний концессын хэлцлийн янз бүрийн төлөв байдлуудтай холбоотой тодруулгыг одоо мөрдөж буй Стандартуудад авч үзсэн байж болно. Энэ Стандарт нь үйлчилгээний концессын хэлцэлтэй холбоотой зөвхөн нэмэлт тодруулгыг авч үздэг. Үйлчилгээний концессын хэлцлийн тодорхой нэг төлөв байдлын тайлагналыг өөр Стандартад авч үзсэн тохиолдолд эрх бүхий этгээд нь 32-р параграфт заасан шаардлагуудаас гадна тэрхүү Стандартын тодруулгын шаардлагуудыг баримтална.
- МЗУ66. УСНББОУС 1 нь санхүүгийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусад нь толилуулахыг шаарддаг. 21-р параграфын дагуу тодорхойлсон санхүүгийн зардлыг энэхүү мөрийн зүйлд тусган оруулна.
- МЗУ67. 31-33-р параграфуудад дурдсан тодруулгаас гадна эрх бүхий этгээд нь энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардалд хамааралтай бол бусад УСНББОУС-уудад заасан, толилуулгын болон тодруулгын холбогдох шаардлагуудыг даган мөрдөнө.

### **Шилжилтийн нөхцөл (34–35-р параграфыг үзнэ үү)**

МЗУ68. [Хассан]

МЗУ69. [Хассан]

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

МЗУ70. [Хассан]

МЗУ71. [Хассан]

МЗУ72. [Хассан]

МЗУ73. [Хассан]



## **Хавсралт Б**

### **Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт**

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 32-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Зорилго

ДҮ1. Концессын хэлцлийг зохицуулдаг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт байхгүй тохиолдолд улсын секторын байгууллагууд нь олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн бусад стандартуудыг харгалзахын тулд УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Топилуулга*-ыг баримтална. Хувийн хэвшлийн оролцоо бүхий хэлцлийн хувьд, улсын секторын байгууллагууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хорооны Тайлбар 12 (СТОУТХ 12), *Үйлчилгээний Концессын Хэлцэл*-д заасан зарчмуудыг мөрдөхийг эрмэлзэнэ. Гэвч СТОУТХ 12 нь эзэмшигчийн нягтлан бодох бүртгэлийг авч үздэг бөгөөд иймээс эрх бүхий этгээдэд зориулсан заавар удирдамжаар хангадаггүй. Энэ Стандарт нь үйлчилгээний концессын хэлцлийг улсын секторын байгууллагууд хэрхэн тайлагнах талаар тууштай ба зэрэгцүүлэгдэх байдлыг бүрдүүлнэ гэдэгт УСНББОУС3 найдаж байна.

### Цар хүрээ

ДҮ2. 2008 оны 3 дугаар сарын Зөвлөлдөх Баримт Бичиг, *Үйлчилгээний Концессын Хэлцлийн Нягтлан Бодох Бүртгэл ба Санхүүгийн Тайлагнал*-ыг боловсруулах явцад тогтоосон, улсын болон хувийн секторын байгууллагуутай холбоотой хэлцлийн янз бүрийн төрлүүдийг харгалзан үзсэний эцэст, УСНББОУС3 нь энэ Стандартын цар хүрээ бол СТОУТХ 12-ын, ялангуяа үйлчилгээний концессын хөрөнгийг эрх бүхий этгээд хүлээн зөвшөөрөх шалгуурын хувьд түүний толин тусгал байна гэж дүгнэсэн (ДҮ11-ДҮ16-р параграфыг үзнэ үү). Ийм дүгнэлтийн шалтгаан үндэслэл нь: үйлчилгээний концессын хэлцэлд ашигладаг хөрөнгийг аль тал хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо нэг ижил зарчим баримтлахыг тухайн хэлцлийн оролцогч хоёр талын аль алианаас энэхүү хандлагаар шаарддаг явдал юм. Иймээс 9-р параграфт (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфт) заасан үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдахгүй байх хэлцлүүд нь энэ Стандартын цар хүрээнд хамарахгүй. Энэхүү хандлага нь хөрөнгийг хоёр талын аль аль нь тайлагнах, эсвэл аль ч тал нь тайлагнахгүй байх боломжит байдлыг хамгийн бага болгоно гэж УСНББОУС3 үзсэн.

ДҮ3. Тус Стандартын цар хүрээнд хамаарахгүй хэлцлүүдэд мөрдөгдөх холбогдох УСНББОУС-уудын талаархи Хэрэгжүүлэх Заавар Удирдамжаар энэ Стандарт нь хангавал зохино гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн. Хэрэгжүүлэх Заавар Удирдамж нь энэ Стандартын мөрдөлтийг үлгэрчлэн харуулсан блок схем, түүнчлэн энэ Стандартын

цар хүрээнд хамаарахгүй бусад төрлийн хэлцлүүдийн хувьд холбогдох УСНББОУС-уудын талаархи лавлагаа бүхий хүснэгтийг агуулсан байдаг.

- ДҮ4. Үйлчилгээний концессын хөрөнгийн хариуд эрх бүхий этгээд нь эзэмшигчид өгөх төлбөрийн тайлагналын талаархи заавар удирдамжаар хангах нь чухал ач холбогдолтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Нөхөн төлбөр нь мөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийн тодорхойлж болох цуврал төлбөрүүдийг авах эрх, эсвэл үйлчилгээний концессын хөрөнгийг гуравдагч талын хэрэглэгчдэд ашиглуулснаар эсвэл орлого бий болгодог бусад хөрөнгийг өөрөө ашигласнаар орлого олох эрх, эсвэл энэхүү хоёр төрлийн төлбөрийн хослолыг тухайн эзэмшигчид олгож болох юм. Нөхөн төлбөрийн төрөл нэг бүр нь нягтлан бодох бүртгэлийн тусгай асуудал үүсэхэд хүргэх бөгөөд УСНББОУСЗ нь энэ Стандартын тууштай мөрдөлтөнд туслахын тулд тэдгээр асуудлуудын талаархи заавар удирдамжаар хангадаг.
- ДҮ5. УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-д заасан, орлогын хүлээн зөвшөөрөлтийн ерөнхий зарчмуудыг үйлчилгээний концессын хэлцэлд мөрдөхөд зарим үйлчилгээний концессын хэлцлийн өвөрмөц шинж чанараас (жишээлбэл; орлого хуваалцах хэлцлээс) хамааран ийм заавар удирдамж зайлшгүй шаардлагатай гэж УСНББОУСЗ бас дүгнэсэн.
- ДҮ6. Эзэмшигчийн нягтлан бодох бүртгэлийг СТОУТХ 12-д авч үзсэн учраас эзэмшигчийн нягтлан бодох бүртгэлийг энэ Стандартад тусгайлан заагаагүй. Эзэмшигч нь ихэнх тохиолдолд хувийн хэвшлийн байгууллага байдаг бөгөөд УСНББОУС-уудыг хувийн хэвшлийн байгууллагуудад мөрдөх зориулалтгүй болно. Эзэмшигч эсвэл эрх бүхий этгээд нь [Улсын Үйлдвэрийн Газар (УҮГ)] (2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргаснаас хойш дээрх дөрвөлжин хаалтанд тусгасан нэр томъёог ашиглахаа больсон) байж болно. Энэ Стандартыг гарах үед УСНББОУС-уудыг УҮГ-т мөрдөх зорилгогүй байсан. Хувийн хэвшлийн байгууллагууд болон УҮГ-уудад Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ыг мөрдөнө.
- ДҮ7. Саналын Төсөл (СТ) 43-д хариу өгсөн зарим хүмүүс нь улсын секторын байгууллагуудын хоорондох үйлчилгээний концессын хэлцлийг тусган оруулахын тулд энэхүү санал болгосон Стандартын цар хүрээг өргөтгөх санал гаргаж байсан. Ийм хэлцлийн тайлагналыг авч үзэх нь энэ төслийн үндсэн зорилго биш гэдгийг УСНББОУСЗ цохон тэмдэглэсэн. Төслийн үндсэн зорилго бол эрх бүхий этгээд нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрддөг улсын секторын байгууллага байх тохиолдлыг авч үзэх явдал байсан. УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны 12-15-р параграфт заасанчлан, энэ Стандартыг улсын секторын эрх бүхий этгээдийн хувьд ижил төсөөтэй байдлаар мөрдөх нь тохиромжтой бөгөөд улсын секторын эзэмшигч нь үйлчилгээний концессын хэлцлийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

холбогдох стандартыг мөрдөж болно гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн.

### Тодорхойлолт

- ДҮ8. СТОУТХ 12-т нэр томъёоны тодорхойлолтыг тусгаагүй тул СТ 43-т мөн тодорхойлолтыг оруулаагүй байсан. Иймээс зарим нэр томъёоны талаархи заавар удирдамжийг СТ 43-т тусгасан. СТ 43-т хариулт өгсөн хүмүүс нь энэ бол Тайлбар биш, харин Стандарт, иймээс стандартын мөрдөлтийн тууштай байдалд зориулан нэр томъёоны тодорхойлолтыг оруулах нь чухал ач холбогдолтой гэсэн санал гаргасан. Энэ Стандартад нэр томъёоны тодорхойлолтыг оруулах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ9. Хэдийгээр СТОУТХ 12 нь “дэд бүтэц” гэсэн нэр томъёог ашигладаг боловч УСНББОУСЗ нь үйлчилгээний концессын хэлцэлд ашигладаг хөрөнгийг илэрхийлэхдээ “дэд бүтэц” нэр томъёо ашиглахгүй байхаар шийдвэрлэсэн. Уг нэр томъёог энэ Стандартад бүрэн нийцэхгүй байж болох тийм байдлаар бусад УСНББОУС-уудад ашигладаг гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Түүнчлэн, зарим улсын хувьд уг нэр томъёо нь СТОУТХ 12-т ашигласнаас өөр утгатай байдаг. Энд дурдсан хөрөнгө нь энэ Стандартын 9-р параграфт (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфт) заасан, хүлээн зөвшөөрөлтийн нөхцлүүдэд үндэслэн хүлээн зөвшөөрсөн хөрөнгө гэдгийг тодорхой болгохын тулд энэ Стандартад дурдсан хөрөнгө гэдэг нь “үйлчилгээний концессын хөрөнгө”-ийг илэрхийлнэ. Энэхүү нэр томъёо нь СТОУТХ 12-т заасантай ижил төрлийн хөрөнгийг тусган агуулах зорилготой байна.
- ДҮ10. “Заавал биелүүлэх хэлцэл” гэсэн нэр томъёог өмнө нь тодорхойлоогүй байсан боловч хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адилтгах эрх, үүргийг бий болгодог хэлцлийг илэрхийлэхийн тулд бусад УСНББОУС-д ашигладаг. Стандартын тууштай мөрдөлтийг хангахын тулд уг нэр томъёог энэ Стандартын зорилгоор тодорхойлох хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

### Үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт

- ДҮ11. Үйлчилгээний концессын хэлцлийн хувьд нягтлан бодох бүртгэлийн гол асуудал нь үйлчилгээний концессын хөрөнгийг эрх бүхий этгээд хүлээн зөвшөөрөх эсэх юм.
- ДҮ12. Эрх бүхий этгээд нь тухайн концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг үнэлэхийн тулд УСНББОУСЗ нь эрсдэл, урамшууллын болон хяналтанд суурилсан арга хандлагын зохистой байдлыг харгалзан үзсэн. Эрсдэл, урамшууллын арга хандлага нь тухайн хэлцлийн нөхцөл, болзлуудын эдийн засгийн төлөв байдалд голлон чиглэдэг. Эрх бүхий этгээдийн зүгээс авч үзвэл, үйлчилгээний концессын хөрөнгийн үндсэн зорилго нь тэрхүү хөрөнгөөр бий болох орлого (жишээлбэл; хэрэглэгчдийн төлбөр) гэх мэт эдийн засгийн үр өгөөж бүрдүүлэх биш,

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

харин тухайн үйлчилгээний концессын хөрөнгийг ашиглаж, тусгайлан заасан төрийн үйлчилгээг эрх бүхий этгээдийн нэрийн өмнөөс үзүүлэх явдал тул ийм хандлага чиглэл нь үйлчилгээний концессын хэлцлийн хувьд тохиромжтой гэж УСНББОУСЗ үздэггүй. Иймээс хөрөнгийн үйлчилгээний чадавхи нь эрх бүхий этгээдэд хуримтлагдан бий болдог. Үйлчилгээний концессын хөрөнгө эсвэл орлого бий болгодог бусад хөрөнгийг гуравдагч талын хэрэглэгчдэд ашиглуулснаар орлого олох эрхийг тухайн эзэмшигчид олгодог зөвхөн тийм тохиолдолд уг үйлчилгээний концессын хэлцлээс эдийн засгийн үр өгөөж үүсэх магадлалтай байдаг. Хяналтанд суурилсан арга хандлага нь уг үйлчилгээний концессын хөрөнгийн эдийн засгийн үр өгөөж болон үйлчилгээний чадавхид тавих хяналтанд голлон чиглэдэг.

- ДҮ13. Эрх бүхий этгээд ба эзэмшигчийн хооронд эрсдлийг хуваалцахын тулд үйлчилгээний концессын хэлцлийг байгуулах тохиолдол байнга гардаг учраас тодорхойлж болох тууштай үр дүнд хүрэхийн тулд эрсдэл ба өгөөжийг үнэлэх хангалттай тодорхой шалгуурыг тогтоож болох эсэхэд УСНББОУСЗ бас эргэлзэж байсан. Түүнчлэн, янз бүрийн эрсдэл ба урамшууллыг жинэлэн тогтоох нь төвөгтэй гэж үзсэн. Иймээс УСНББОУСЗ нь эрсдэл, урамшууллын арга хандлагыг тохиромжгүй гэж дүгнэсэн.
- ДҮ14. УСНББОУСЗ нь эрх, үүргийн арга хандлага тохиромжтой эсэхийг мөн авч үзсэн. Хэдийгээр ийм хандлага нь үзэл баримтлалын хувьд ач холбогдолтой боловч улсын секторын байгууллагуудын хөрөнгө, өр төлбөрийн нягтлан бодох бүртгэл ба санхүүгийн тайлагналд мэдэгдэхүйц өөрчлөлт оруулах бөгөөд үйлчилгээний концессын хэлцлээс давсан утга агуулгатай байж болох юм гэж УСНББОУСЗ үзсэн. Хяналтауд суурилсан хандлагыг ашигладаг СТОУТХ 12-ыг хэрэгжүүлэх өөрийн шийдвэрийг харгалзан УСНББОУСЗ нь энэ Стандартын хувьд эрх, үүргийн арга хандлага тохиромжгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ15. Эрх бүхий этгээд нь хөрөнгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг тодорхойлоход хяналтанд суурилсан арга хандлага нь хамгийн үр дүнтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Хэрэв хяналтанд суурилсан хандлагыг ашиглавал энэ нь ДҮ2-т иш татсан учир шалтгааны үр дүнд СТОУТХ 12-той нийцнэ гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс эрх бүхий этгээд нь (а) эзэмшигчийн үзүүлэх үйлчилгээг хянадаг буюу зохицуулдаг, (б) тухайн хэлцлийн хугацааны эцэст уг үйлчилгээний концессын хөрөнгөнд үлдэх аливаа мэдэгдэхүйц хувь оролцоог хянадаг, зөвхөн тийм хэлцлийг энэ Стандартад авч үзсэн. Ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд СТОУТХ 12-той нийцүүлэн үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийн тулд зөвхөн (а)-д дурдсан нөхцөл биелэгдсэн байх ёстой. Үйлчилгээний концессын хэлцэл нь заавал биелүүлэх хэлцэл гэдгийг онцлон тэмдэглэх нь ач холбогдолтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх эсэх үнэлгээг тухайн хэлцлийн бүх баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн гаргана.

ДҮ16. Энэ Стандартын 9(а) параграф нь СТОУТХ 12-ын 5-р параграфтай нийцдэг. Энэ параграфыг эрх бүхий этгээдийн зүгэс авч үзсэн улсын секторын зохицуулалтын бүрэн эрхийн ерөнхий ойлголтонд бус, харин үйлчилгээний концессын хэлцэлд тусгайлан хамаарах зохицуулалтанд зөвхөн мөрдөх санаа зорилготой юм. Энэ Стандартын 9(а) параграфт дурдсан зохицуулалт нь гэрээгээр эсвэл зохицуулагчаар дамжин хэрэгжинэ. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг тодорхойлохын тулд 9(а) параграфт дурдсан “зохицуулах” нэр томъёог мөрдөх заавар удирдамжийг МЗУ6-р параграфт тусгасан. Энэ нэр томъёоны утгын талаархи нэмэлт заавар удирдамж СТОУТХ 12-д байдаггүй тул ийм нэмэлт заавар удирдамжийг оруулах нь СТОУТХ 12-той үл нийцэх байдал үүсгэнэ гэж СТ 43-т хариулт өгсөн зарим хүмүүс үзэж байсан. Улсын сектор нь уг нэр томъёог засгийн газрын ерөнхий зохицуулалтын бүрэн эрхийн хүрээнд авч үзэж болох учраас улсын секторын эрх бүхий этгээд ба хувийн хэвшлийн эзэмшигч нь үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо “зохицуулах” гэсэн шалгуурыг мөрдөхөд нийцтэй байдал үүссэн эсэхийг ханган магадлахад МЗУ6-р параграфт тусгасан, нэмэлт заавар удирдамж зайлшгүй шаардлагатай гэж УСНББОУСЗ үзсэн.

#### **Өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт**

ДҮ17. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийн хариуд тухайн эзэмшигчид төлөх нөхөн төлбөрийн шинж төрөлд үндэслэн үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх үед өр төлбөр үүсэхэд хүргэж болох хоёр нөхцөл байдлыг СТ 43-д тайлбарласан байдаг.

ДҮ18. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө гэж СТ43-д заасан. Энэхүү өр төлбөр нь санхүүгийн өр төлбөр ба гүйцэтгэлийн үүргийн дурын хослол байж болно гэдгийг уг СТ-д тэмдэглэсэн. Эрх бүхий этгээд нь эзэмшигчид өгөх мөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийн тодорхойлж болох цуврал мөнгөн төлбөрүүдтэй тохиолдолд санхүүгийн өр төлбөр үүснэ, харин эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгийг ашиглуулснаар хэрэглэгчдээс төлбөр авах эрхийг эзэмшигчид олгох, эсвэл орлого бий болгодог хөрөнгийг өөрөө ашиглахын тулд хандан нэвтрэх эрхийг эзэмшигчид олгох замаар түүнд нөхөн төлбөр олгодог тохиолдолд гүйцэтгэлийн үүрэг үүснэ гэж СТ 43-д санал болгосон байдаг. СТ 43-д санал болгосноор, эрх бүхий этгээд нь уг гүйцэтгэлийн үүргийг УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу тайлагнана.

ДҮ19. СТ 43-т хариулт өгсөн хүмүүс нь энэ асуудлыг, ялангуяа СТ 43-д тодорхойлсон “гүйцэтгэлийн үүрэг”-ийн талаар илүү тодотгохыг хүссэн. Хариулт өгсөн хүмүүсийн гол санаа зовж буй зүйлсийг доор товчоолон илэрхийлэв:

- (а) Үйлчилгээний концессын хөрөнгийн хэрэглэгчдээс төлбөр авах эрх эсвэл орлого бий болгодог бусад хөрөнгийг уг эзэмшигч ашиглах

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

эрх олголт нь тухайн хөрөнгийн нөхөн төлбөртэй хамааралгүй гэж зарим хүмүүс үзэж байсан. Хөрөнгө ашиглах эрх олгоход тавигдах шаардлага нь ихэнх концессын хэлцлийн гол шинж бөгөөд хэрэв үүнийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай бол ийм хүлээн зөвшөөрөлт нь эрх бүхий этгээдээс тухайн эзэмшигчид олгох төлбөрийн гүйлгээ хийгдэх эсэхээс хамааралтай байх ёсгүй гэдгийг тэдгээр хүмүүс онцлон тэмдэглэсэн.

- (б) Гүйцэтгэлийн үүрэг гэж нэрлэж байгаа боловч эрх бүхий этгээдээс ирээдүйн тайлант үеүдэд эдийн засгийн нөөцийг зарцуулах үүрэг үүсээгүй байна. Иймээс эдгээр хүмүүс нь УСНББОУС 1-д тодорхойлсон өр төлбөр эсвэл УСНББОУС 19-д тодорхойлсон нөөц оршин байгаа гэдгийг бодитойгоор төлөөлөн илэрхийлж чадах эсэхэд эргэлзэж байсан.
- ДҮ20. Түүнчлэн, хариулт өгсөн бусад олон хүмүүс нь магадгүй дээр дурдсан санаа зовж буй асуудлын үр дүнд уг СТ-д тусгасан, “гүйцэтгэлийн үүрэг”-ийн утга агуулгыг илүү тодорхой болгохыг хүссэн. Цөөн зарим хүмүүс нь энэхүү “харилцан нөхөх зүйл”-ийн шинж төрөл нь мөн чанарын хувьд хойшлогдсон орлого эсэхийг асууж байсан.
- ДҮ21. Энэ асуудлыг тодруулах шаардлагатай гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн. “Гүйцэтгэлийн үүрэг” нэр томъёог УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-д арилжааны бус ажил гүйлгээтэй холбоотойгоор ашигласан тул уг нэр томъёог энд ашиглах нь төөрөгдөлд хүргэж болзошгүй гэдгийг УСНББОУС3 цохон тэмдэглэсэн. Үйлчилгээний концессын хэлцэл нь арилжааны бус ажил гүйлгээ биш, харин арилжааны ажил гүйлгээ учраас арилжааны ажил гүйлгээтэй холбоотойгоор гүйцэтгэлийн үүрэг нэр томъёо ашиглахгүй байх нь илүү зохистой гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн.
- ДҮ22. СТОУТХ 12-т зааснаар, хэрэв эзэмшигч нь үйлчилгээний концессын хөрөнгийг хянадаггүй бол тухайн эзэмшигч нь эрэлтийн эрсдлийг аль тал хариуцаж байгаагаас хамааран түүнийг санхүүгийн хөрөнгө эсвэл биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг. СТОУТХ 12-той нийцүүлэхийн тулд эрх бүхий этгээдийн хувьд мөн уг хандлагыг мөрдөх хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн. Иймээс эрх бүхий этгээд нь энэ Стандартын дагуу үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тохиолдолд эх үүсвэр талыг тайлагнахад зориулан санхүүгийн өр төлбөрийн загвар, эзэмшигчид эрх олгох загвар (энэ нь “гүйцэтгэлийн үүрэг”-ийг орлосон) гэсэн хоёр загварыг тодорхойлсон.
- ДҮ23. СТ43-д ашигласан “гүйцэтгэлийн үүрэг” нэр томъёог энэ Стандартад “өр төлбөр” болгон өөрчлөх УСНББОУС3-ийн шийдвэр нь уг СТ 43-д санал болгосон, үйлчилгээний концессын хэлцлийг тайлагнах эрх бүхий этгээдийн нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг өөрчлөхгүй юм.

*Санхүүгийн өр төлбөрийн загвар*

- ДҮ24. Эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгө дэх өөрийн хяналтын хариуд мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг эзэмшигчид өгснөөр түүнд нөхөн төлбөр олгодог тохиолдолд уг эзэмшигч нь санхүүгийн хөрөнгө хүлээн авч байгаа учраас энэ төрлийн хэлцлийг СТОУТХ 12-т “санхүүгийн хөрөнгийн загвар” гэж ангилдаг. Харин эрх бүхий этгээд нь санхүүгийн өр төлбөртэй болох тул ийм төрлийн хэлцлийг энэ Стандартад “санхүүгийн өр төлбөрийн загвар” гэж нэрлэдэг.
- ДҮ25. Эрх бүхий этгээд нь уг заавал биелүүлэх хэлцлийн үр дүнд мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өөр байгууллагад (эзэмшигчид) өгөх үүрэгтэй тул тухайн эзэмшигч нь тодорхойлж болох цуврал төлбөрүүдийг эзэмшигчид олгох үүрэгтэй болсон үед санхүүгийн өр төлбөр үүсдэг. Түүнчлэн, мөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийн тодорхойлж болох цуврал төлбөрүүд байгаа тохиолдолд тэдгээр төлбөрүүдийг уг өр төлбөрийн бууралт, тооцоолсон санхүүгийн зардал болон тэрхүү үйлчилгээний концессын хэлцлийн дагуу эзэмшигчийн үзүүлсэн үйлчилгээний төлбөр байдлаар хуваарилах хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.
- ДҮ26. Үйлчилгээний концессын хэлцлийг заавал биелүүлэх хэлцэл хэлбэрээр байгуулдаг. Энэ нь хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адилтгах эрх, үүргийг бий болгодог гэрээ болон бусад хэлцлийг агуулсан байж болно. Хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адилтгах эрх, үүргийг бий болгодог бусад хэлцэл байх тохиолдолд ийм хэлцэлд УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*, УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*, УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ыг мөн адил мөрдөх хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.
- ДҮ27. СТОУТХ 12-ын энэхүү төлөв байдлаас гажилтыг авч үзэхдээ, УСНББОУСЗ нь энэхүү Стандартыг боловсруулах “толин тусгал” хандлагад хамаарах СТОУТХ 12-ын гол шинжүүд нь хамаарах хэлцлийн цар хүрээ, хүлээн зөвшөөрөлтийн болон тодруулгын шаардлагуудаар хязгаарлагдана гэдгийг онцлон тэмдэглэсэн.
- ДҮ28. СТОУТХ 12 нь санхүүгийн хэрэглүүрүүдийн талаархи СТОУС-ын дагуу санхүүгийн хөрөнгийг тайлагнахыг шаарддаг. Энэ Стандарт нь санхүүгийн өр төлбөрийн загварын дагуу санхүүгийн зардлыг тодорхойлоход ашиглах хүүний түвшинг тодорхойлох заавар удирдамжаар хангадаг. УСНББОУСЗ нь зах зээлийн хүүний түвшинг тодорхойлох хангалттай мэдээлэл эрх бүхий этгээдэд ихэвчлэн байдаггүй гэж үзсэн. Иймээс уг заавар удирдамж нь хэрэв тодорхойлох боломжтой бол тухайн эзэмшигчийн капиталын өртгийг ашиглахыг шаарддаг. Мөн тухайн үйлчилгээний концессын хэлцлийн тодорхой нөхцөл, болзолд тохиромжтой бусад хүүний түвшинг ашиглахыг зөвшөөрдөг.



*Эзэмшигчид эрх олгох загвар*

- ДҮ29. Үйлчилгээний концессын хөрөнгө буюу орлого бий болгодог бусад хөрөнгийг гуравдагч талд ашиглуулж, орлого олсноор тухайн хөрөнгийн үнийг эзэмшигч нөхдөг тохиолдолд уг үйлчилгээний концессын хөрөнгийн хувьд эрх бүхий этгээдийн өгсөн төлбөрийн шинж төрлийг УСНББОУСЗ нь СТ 43-д хариу өгсөн хүмүүсийн дэвшүүлсэн асуултуудын хариу болгон дахин авч үзсэн. Энэ тохиолдолд үйлчилгээний концессын хөрөнгийн хувьд мөнгөн төлбөрийг тухайн эрх бүхий этгээд биш, харин үйлчилгээний концессын хөрөнгө эсвэл орлого бий болгодог бусад хөрөнгийн хэрэглэгч нар төлж байна гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Ийм хэлцлийн эдийн засгийн мөн чанар нь тухайн эрх бүхий этгээдийн цэвэр хөрөнгө өсөхөд хүргэж байгаа учраас орлого хуримтлагдан бий болох бөгөөд үүнийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Үйлчилгээний концессын хэлцэл нь арилжааны ажил гүйлгээ тул Зөвлөл нь орлогын шинж төрөл ба уг орлогын хүлээн зөвшөөрөлтийн хугацааг харгалзан үзэхдээ УСНББОУС 9-ийг лавлагаа болгодог.
- ДҮ30. Эзэмшигч нь эрэлтийн эрсдлийг хариуцдаг тохиолдолд эрх бүхий этгээд нь үйлчилгээний концессын хөрөнгөтэй холбоотой төрийн үйлчилгээ эсвэл орлого бий болгодог бусад хөрөнгийн хэрэглэгчдээс төлбөр авах эрх (лиценз)-ийг өгснөөр уг эзэмшигчид нөхөн төлбөр олгодог. Үйлчилгээний концессын хөрөнгийн барьж байгуулалт, хөгжүүлэлт, худалдан авалт, сайжруулалтын хувьд эзэмшигчид нөхөн төлбөр олгохын тулд эрх бүхий этгээд нь тухайн хөрөнгийг ашиглах эрхийг эзэмшигчид олгодог. СТОУТХ 12 нь энэ төрлийн хэлцлийг “биет бус хөрөнгийн загвар” гэж ангилдаг. Энэ Стандартад ийм төрлийн хэлцлийг “эзэмшигчид эрх олгох загвар” гэж нэрлэсэн.
- ДҮ31. Иймээс УСНББОУСЗ нь уг кредитийг өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн шууд нэмэгдэлт, эсвэл орлого гэж тайлагнах эсэхийг авч үзсэн.
- ДҮ32. Үйлчилгээний концессын хэлцэл нь тухайн хөрөнгийг уг үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд гуравдагч талын хэрэглэгчдэд ашиглуулснаар орлого олох эрхийг эзэмшигчид шилжүүлсэний хариуд үйлчилгээний концессын хөрөнгийг эрх бүхий этгээд олж эзэмшдэг хөрөнгийн солилцоо учраас энэ тохиолдолд эзэмшигч нь өр төлбөргүй байна гэдгийг хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ33. СТ 43-д хариу өгсөн зарим хүмүүс нь уг кредитийг цэвэр хөрөнгө/өмч гэж үзэх нь УСНББОУС 1-тэй нийцнэ гэсэн санал дэвшүүлсэн. УСНББОУС 1 нь цэвэр хөрөнгө/өмчийг тухайн байгууллагын бүх өр төлбөрийг хассаны дараа түүний хөрөнгөнд үлдэх хувь оролцоо гэж тодорхойлдог. УСНББОУС 1 нь цэвэр хөрөнгө/өмчийн дөрвөн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлсон байдаг. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь:
- (а) Хувь нийлүүлсэн хөрөнгө, энэ нь тухайн тайлангийн өдрөөрх эздийн оруулсан хувь оролцооноос эздэд олгосон хуваарилалтыг хассан, нийт хуримтлагдсан дүн байна;

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

- (б) Хуримтлагдсан ашиг буюу алдагдал;
- (в) Нөөц сан, үүнд: цэвэр хөрөнгө/өмчийн хүрэн дэх нөөц сан тус бүрийн шинж төрөл ба зорилгын талаархи тайлбар тодорхойлолт; ба
- (г) Хяналтын бус хувь оролцоо.

ДҮ34. Кредит нь доор дурдсан шалтгааны улмаас ДҮ33-р параграфт тодорхойлсон цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг болохгүй тул түүнийг тухайн эрх бүхий этгээдийн цэвэр хөрөнгө/өмчийн шууд нэмэгдэлт биш гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Үүнд:

- (а) Эздийн оруулсан хувь оролцоог “гаднын талуудаас тухайн байгууллагад өр төлбөр үүсгэхээс бусад байдлаар түүнд оруулсан ба уг байгууллагын цэвэр хөрөнгө/өмч дэх санхүүгийн хувь оролцоог тогтоодог, ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бөгөөд энэ нь (а) дараах зүйлсийн аль алианаас авах эрхийг олгодог: (i) тухайн эзэд буюу тэдний төлөөлөгчдийн саналаар, уг байгууллага өөрийн үйл ажиллагааны явцад хийх ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн хуваарилалт, (ii) уг байгууллага татан буугдах тохиолдолд түүний өр төлбөрөөс давсан аливаа хөрөнгийн хуваарилалт; ба/буюу (б) борлуулах, солилцох, шилжүүлэх буюу эргэлтээс гаргах боломжтой байна” гэж тодорхойлдог. Эзэмшигч нь УСНББОУС 1-д заасанчлан, тухайн байгууллагад санхүүгийн хувь оролцоотой болоход хүргэх тийм хувь оролцоог уг эрх бүхий этгээдэд оруулаагүй учраас үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлттэй холбоотой кредит нь энэ тодорхойлолтыг хангахгүй.
- (б) Хуримтлагдсан ашиг/алдагдал нь тухайн байгууллагын ашиг, алдагдлын хуримтлал юм. Үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлттэй холбоотой кредит нь хуримтлалыг биш, харин бие даасан ажил гүйлгээг илэрхийлдэг.
- (в) Нөөц сан нь УСНББОУС-ын тодорхой шаардлагуудын улмаас цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн зүйлсээс ерөнхийдөө үүсдэг бөгөөд тухайлбал, хөрөнгийн (жишээлбэл; үндсэн хөрөнгийн) дахин үнэлгээний олз, гарзыг агуулсан байж болно. Үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт буюу дахин ангилалтай холбоотой кредит нь эрх бүхий этгээдийн одоо байгаа хөрөнгийн дахин үнэлгээ биш, харин арилжааны ажил гүйлгээтэй холбоотой учраас цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөхөөр заасан олз, гарзыг илэрхийлэхгүй. Энэ Стандартад заасан хяналтын шалгуурыг хангасан хэвээр байгаа уг эрх бүхий этгээдийн одоо байгаа хөрөнгийг үйлчилгээний концессын хэлцэлд ашиглах үед дахин ангилдаг ба иймээс дахин үнэлгээ хийдэггүй.
- (г) Хяналтын бус хувь оролцоог “хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагуудаар дамжуулан шууд буюу шууд бусаар өмчилдөггүй цэвэр хөрөнгө/өмчид хамааруулж болох уг

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

хяналтанд буй байгууллагын ашиг, алдагдал ба цэвэр хөрөнгө/өмчийн хэсэг” гэж тодорхойлдог. Жишээлбэл; засгийн газрын түвшинд эдийн засгийн нэгдмэл байгууллага нь хэсэгчлэн хувьд шилжсэн улсын секторын худалдаа арилжааны байгууллагыг өөртөө агуулдаг тохиолдолд хяналтын бус хувь оролцоо үүсэж болно. Ингэснээр уг байгууллагын цэвэр хөрөнгө/өмчид санхүүгийн хувь оролцоотой хувийн хэвшлийн хувьцаа эзэмшигчид байж болох юм. Эзэмшигч нь тухайн эрх бүхий этгээдэд ийм санхүүгийн хувь оролцоогүй учраас үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлттэй холбоотой кредит нь энэ тодорхойлолтыг хангахгүй.

- ДҮ35. Кредит нь орлогыг илэрхийлнэ гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Үйлчилгээний концессын хэлцэл нь арилжааны ажил гүйлгээ тул УСНББОУСЗ нь орлогын шинж төрөл ба уг орлогын хүлээн зөвшөөрөлтийн хугацааг харгалзан үзэхдээ УСНББОУС 9-ийг лавлагаа болгодог. УСНББОУС 9-д заасанчлан, ижил төсөөтэй бус бараа, үйлчилгээний солилцоогоор барааг борлуулсан буюу үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд уг ажил гүйлгээ нь тухайн эрх бүхий этгээдийн цэвэр хөрөнгийг нэмэгдүүлэх үр дүнтэй тул түүнийг орлого бий болгодог ажил гүйлгээ гэж үзнэ. Энэ тохиолдолд эрх бүхий этгээд нь түүний нэрийн өмнөөс үзүүлэх төрийн үйлчилгээний гуравдагч талын хэрэглэгчдээс төлбөр авах эрх (лиценз)-ийг уг эзэмшигчид өгсөний хариуд үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн авдаг. Эрх бүхий этгээдийн хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний концессын хөрөнгө ба эзэмшигчийн хүлээн зөвшөөрсөн эрх (биет бус хөрөнгө) нь хоорондоо ижил төсөөгүй байдаг. Гэвч орлогыг хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдах хүртэл уг кредитийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- ДҮ36. УСНББОУСЗ нь энэ тохиолдолд уг хүлээн зөвшөөрсөн орлоготой тэнцүү мөнгөн орлогын гүйлгээ байхгүй байна гэдгийг онцлон тэмдэглэсэн. Энэхүү үр дүн нь УСНББОУС 9-тэй нийцэх бөгөөд энд уг байгууллага нь дараагийн тайлант үеүдэд мөнгөн орлогын гүйлгээ бий болгохын тулд ашиглах ижил төсөөгүй өөр нэг хөрөнгийн хариуд бараа, үйлчилгээг нийлүүлж байна.
- ДҮ37. Орлогыг хүлээн авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнээр хэмждэг бөгөөд шилжүүлсэн аливаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дүнгээр түүнийг тохируулдаг. Хүлээн авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй тохиолдолд орлогыг тухайн өгсөн бараа, үйлчилгээний бодит үнэ цэнээр хэмжиж, шилжүүлсэн аливаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дүнгээр тохируулдаг.
- ДҮ38. Орлого бий болгодог гурван төрлийн ажил гүйлгээг УСНББОУС 9-д тодорхойлсон байдаг. Үүнд: үйлчилгээ үзүүлэх, бараа (эсвэл бусад хөрөнгө) борлуулах, тухайн байгууллагын хөрөнгийг бусдад ашиглуулснаар орлого олох, үүн дотроо хүү, эрхийн шимтгэл, ногдол ашгийн орлого олох. Орлогын шинж төрлийг тогтоохдоо, УСНББОУСЗ нь ажил гүйлгээний эдгээр төрлүүдийг тус тусад нь авч үздэг.

- ДҮ39. УСНББОУСЗ нь УСНББОУС 9-д заасан орлогын хүлээн зөвшөөрөлтийн хандлагуудыг “эзэмшигчид эрх олгох” загвартай холбоотойгоор авч үзсэн бөгөөд тэдгээр хувилбаруудын аль нь ч энэ загварын нөхцөл байдлыг бүрэн хангахгүй байна гэж дүгнэсэн. Гэвч хувилбар нэг бүрийн дагуу орлогыг хүлээн зөвшөөрөх хугацаа нь нэн даруй биш, харин хэлцлийн хугацааны туршид байна гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Орлогын хүлээн зөвшөөрөлтийн ийм хэв маяг нь энэхүү загвартай холбоотой өр төлбөрөөс үүсэх орлогын хүлээн зөвшөөрөлтийн хувьд мөн тохиромжтой гэдгийг УСНББОУСЗ нь адилтган тодорхойлсон. Иймээс орлогын хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдах хүртэл уг кредитийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- ДҮ40. Эзэмшигчид эрх олгох загвартай холбоотойгоор эрх бүхий этгээд нь ДҮ30-р параграфт заасан нөхцөл байдалд үйл ажиллагааны зардлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. Эрх бүхий этгээдийн хүлээн зөвшөөрсөн өр төлбөр нь зөвхөн түүний хүлээн авсан үйлчилгээний концессын хөрөнгөтэй холбоотой байна гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Хэрэв үйлчилгээний зардлыг хүлээн зөвшөөрсөн бол эрх бүхий этгээд нь тухайн жилийн зардалтай тэнцүү жил тутам тооцоолсон орлогыг мөн хүлээн зөвшөөрөх ёстой. Ийм нягтлан бодох бүртгэл нь жил тутам орлого ба зардлыг тэнцүү дүнгээр хүлээн зөвшөөрөх учраас ач холбогдолтой мэдээллээр хангана гэж УСНББОУСЗ үзэхгүй байна. Эзэмшигчийн зардлын талаархи найдвартай мэдээлэл нь ямар ч тохиолдолд элэн боломжтой байхгүй байж болох юм гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь ДҮ30-р параграфт дурдсан нөхцөл байдалд үйлчилгээний концессын хэлцэлтэй холбоотойгоор эзэмшигч нь үйл ажиллагааны зардлыг хүлээн зөвшөөрөх хэрэггүй гэж дүгнэсэн.

### **Бусад УСНББОУС-д авч үзсэн нягтлан бодох бүртгэлийн асуудлууд**

- ДҮ41. Үйлчилгээний концессын олон хэлцлийн нарийн цогц байдлаас шалтгаалан тухайн гэрээ буюу адилтгах заавал биелүүлэх хэлцлийн зарим нөхцлүүдтэй (жишээлбэл; орлого, зардал, баталгаа, болзошгүй зүйлстэй) холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн нэмэлт асуудлууд үүсэж болох юм. УСНББОУСЗ нь энэ талаархи одоо байгаа заавар удирдамжуудыг энэ Стандартад дахин давтан тусгах шаардлагагүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Иймээс одоо байгаа УСНББОУС нь үйлчилгээний концессын хэлцлийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд нягтлан бодох бүртгэл ба тайлагналыг тусгайлан заасан тохиолдолд уг УСНББОУС-ыг энэ Стандартад лавлагаа болгон дурдах бөгөөд нэмэлт заавар удирдамжаар хангахгүй. Гэвч үйлчилгээний концессын хэлцлийн зарим өвөрмөц шинж чанарын улмаас ийм УСНББОУС-ын мөрдөлт хүндрэлтэй байх зарим тохиолдлыг (жишээлбэл; орлогын хүлээн зөвшөөрөлт) УСНББОУСЗ тэмдэглэсэн байдаг. Энэ Стандартын тууштай хэрэгжүүлэлтийг хангахын тулд УСНББОУСЗ нь бусад УСНББОУС-д заасан зарчмуудыг хэрхэн мөрдөх талаархи тодорхой заавар удирдамжаар хангасан байдаг.

## Шилжилтийн нөхцөл

- ДҮ42. Үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр, орлого, зардлыг өмнө нь хүлээн зөвшөөрсөн байгууллага нь УСНББОУС 3-д заасанчлан, энэ Стандартыг буцаах горимоор мөрдөхийг энэхүү Стандарт шаарддаг. Үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр, орлого, зардлыг өмнө нь хүлээн зөвшөөрч байгаагүй бөгөөд нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг ашигладаг байгууллага нь санхүүгийн тайландаа зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулсан хамгийн эхний тайлант үеийн эхнээс энэ Стандартыг төсөөлөн тооцсон өртөг ашигласнаар буцаах горимоор эсвэл гүйцээх горимоор мөрдөхийг энэхүү Стандартаар бас шаарддаг.
- ДҮ43. УСНББОУС 3-ын ерөнхий шаардлага нь буцаах горимоор мөрдөх практик боломжгүй байхаас бусад тохиолдолд өөрчлөлтийг буцаах горимоор тайлагнах явдал юм. Буцаах горимоор тодорхойлолт нь дахин ангилал ба дахин хэмжилт гэсэн хоёр төлөв байдалтай байдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. УСНББОУС3-ийн үзэл бодлоор бол эрх бүхий этгээдийн санхүүгийн байдлын тайланд өмнө нь тусгасан бүх дүнгийн зохих ангиллыг буцаах горимоор ихэвчлэн тодорхойлох практик боломжтой, харин үйлчилгээний концессын хөрөнгийг буцаах горимоор дахин хэмжих нь ялангуяа уг үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр, орлого, зардлыг тухайн байгууллага өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд үндсэндээ практик боломжгүй байж болох юм.
- ДҮ44. Буцаан дахин тайлагнах практик боломжгүй тохиолдолд УСНББОУС 3 нь практик боломжтой хамгийн эхний өдрөөс, магадгүй тухайн тайлант үеийн эхнээс гүйцээх горимоор мөрдөхийг шаарддаг гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн байдаг.
- ДҮ45. Үйлчилгээний концессын хэлцлийг өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй байсан байгууллагын хувьд УСНББОУС 3-ын ерөнхий шаардлага мөн тохиромжгүй гэдэгт СТ 43-д хариулт өгсөн зарим хүмүүс эргэлзэж байсан учраас үйлчилгээний концессын хөрөнгийг өмнө нь хүлээн зөвшөөрдөггүй байсан байгууллагуудын хувьд энэ Стандартын шилжилтийн нөхцлийг СТ 43-д тусгаснаас өөрчлөн засварласан. СТ 43 нь ийм тохиолдолд гүйцээх горимоор мөрдөхийг шаарддаг боловч буцаах горимоор мөрдөхийг бас зөвшөөрдөг.
- ДҮ46. СТ 43-ыг боловсруулахдаа УСНББОУС3 нь үйлчилгээний концессын хөрөнгийн хэмжилтийг тодорхойлох практик боломжтой байдалд санаа зовж байсан бөгөөд энэ нь өмнө байгуулсан хэлцлүүдийн хувьд үл нийцэх асуудал үүсгэж болзошгүй гэж үзсэн. Энэ нь УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийг эцэслэн боловсруулах явцад үүсэж байсантай ижил төсөөтэй асуудал юм. Иймээс УСНББОУС3 нь УСНББОУС 31-тэй нийцсэн шилжилтийн нөхцлүүдийг СТ 43-д оруулах нь тохиромжтой гэж үзсэн.

ДҮ47. Гэхдээ биет бус хөрөнгөнд хамаарах нөхцөл байдлууд нь үйлчилгээний концессын хэлцлийн нөхцөл байдлуудаас ялгаатай гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Тухайлбал; үйлчилгээний концессын хэлцэл нь ерөнхийдөө урт хугацаат заавал биелүүлэх хэлцэлтэй холбоотой байдаг бөгөөд хэдийгээр байгууллага нь үйлчилгээний концессын хөрөнгийг өмнө нь хүлээн зөвшөөрдөггүй байсан ч гэсэн түүний бодит үнэ цэнийг тооцоолоход шаардлагатай мэдээлэл ба өртгийн мэдээлэл нь өнгөрсөн хугацаанд олж эзэмшсэн буюу хөгжүүлэн боловсруулсан биет бус хөрөнгөтэй харьцуулахад илүү бэлэн боломжтой байх магадлалтай байдаг.

ДҮ48. Гэвч ийм олон хэлцлүүдийг нилээд олон жилийн өмнө байгуулсан байж болох учраас буцаах горимыг бүрэн мөрдөхөд хүндрэлтэй байж болно гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Иймээс үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ “төсөөлөн тооцсон өртөг” ашиглаж болох эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн.

**УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд-ын Хэсэг II: “Санал гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд”-ын үр дүнд УСНББОУС 32-д хийсэн хянан засварлалт**

ДҮ49. УСНББОУСЗ нь УСНББОУС 32-ын шаардлагууд ба УСНББОУС17, УСНББОУС 31-ийн шаардлагууд хоорондох боломжит уялдаагүй байдалд анхаарал хандуулсан. УСНББОУС 32-ын шаардлагуудын дагуу, хэдийгээр үйлчилгээний концессын хөрөнгүүд нь ижил төсөөтэй бус шинж төрөл ба чиг үүрэгтэй байлаа ч гэсэн тэдгээрийг хөрөнгүүдийн нэг анги байдлаар толилуулна гэж ойлгож болно. Ижил төсөөгүй хөрөнгүүдийг ижил төсөөтэй мэт тайлагнахаар шаардах нь УСНББОУС3-ийн санаа зорилго биш тул УСНББОУСЗ нь өөрийн санаа зорилгыг тодорхой болгох үүднээс УСНББОУС 32-т тодруулга оруулахаар шийдвэрлэсэн. Эдгээр өөрчлөлтүүд нь хэрэглэгчдэд бэлэн боломжтой байх мэдээллийг бууруулах эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн боловч одоогийн тодруулгын шаардлагууд, ялангуяа 32-р параграфт заасан шаардлага нь үйлчилгээний концессын хэлцэлд хамаарах хөрөнгийн талаар өндөр чанартай тодруулга хийх боломжийг бүрдүүлнэ гэдэгт итгэлтэй байсан.

ДҮ50. Үйлчилгээний концессын хөрөнгийн дахин ангилал нь зарим байгууллагын хувьд хэмжилтийн суурийг өөрчлөхөд хүргэж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Жишээлбэл; дахин үнэлгээний загвар ашиглан хэмжсэн үйлчилгээний концессын зарим хөрөнгийг өртгийн загвар ашиглан хэмжсэн хөрөнгүүдийн ангид оруулан дахин ангилж болох юм. Үүнтэй адилаар, өртгийн загвар ашиглан хэмжсэн үйлчилгээний концессын зарим хөрөнгийг дахин үнэлгээний загвар ашиглан хэмжсэн хөрөнгүүдийн ангид оруулан дахин ангилж болно. Нэг ангид байгаа үйлчилгээний концессын хөрөнгө ба бусад хөрөнгүүдийн хоорондох тэнцвэрт харьцаа нь байгууллага бүрд өөр өөр байх учраас дахин ангиллын өдрөөр хэрэглэх хэмжилтийн сууриа байгууллагууд сонгох боломж олгохыг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Мөн өртгийн загварыг буцаах горимоор мөрдөхөд шаардлагатай мэдээлэл нь бэлэн боломжгүй

байж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс байгууллага нь өртгийн загвар ашиглан хөрөнгүүдийн ангийг хэмжих сонголт хийсэн тохиолдолд дахин үнэлгээний загварын дагуу өмнө тодорхойлсон дансны үнийг уг дахин ангиллын өдрөөр төсөөлөн тооцсон өртөг байдлаар ашиглахыг УСНББОУСЗ нь байгууллагуудад зөвшөөрсөн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 32-т хийсэн хянан засварлалт**

ДҮ51. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (a) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү заавар удирдамж нь УСНББОУС 32-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*


ХЗУ1. Энэхүү Хэрэгжүүлэх Заавар Удирдамжийн зорилго нь УСНББОУС 32-ын шаардлагуудын зарим төлөв байдлыг үлгэрчлэн харуулахад оршино.

### **Үйлчилгээний концессын хэлцлийн нягтлан бодох бүртгэлийн хүрээ**

ХЗУ2. УСНББОУС 32-т тодорхойлсон, үйлчилгээний концессын хэлцлийн тайлагналыг дараах схемд үлгэрчлэн харуулав:



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД



**Үзүүлэх үйлчилгээтэй нэгтгэн хослуулсан хөрөнгө бүхий хэлцлийн нийтлэг төрлүүдэд мөрдөх УСНББОУС-ын лавлагаа**

ХЗУ3. Төрийн үйлчилгээ үзүүлэхэд оролцох хувийн хэвшлийн оролцоонд зориулсан хэлцлийн нийтлэг төрлүүд болон тэдгээр хэлцлүүдэд мөрдөх УСНББОУС-уудын лавлагааг доорх хүснэгтэнд харуулав. Уг жагсаалтанд хэлцлийн бүх төрлүүдийг хамруулан тусгаагүй болно. Хүснэгтийн зорилго нь хэлцлүүдийн харилцан холбоог онцлон тэмдэглэхэд оршино. УСНББОУС3-ийн санаа зорилго нь хэлцлийн янз бүрийн төрлүүдэд хамаарах нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудын хооронд тодорхой зааг ялгаа оршин байна гэсэн санааг илэрхийлэх явдал биш юм.

ХЗУ4. Будсан текстүүд нь УСНББОУС 32-ын цар хүрээнд хамаарах хэлцлүүдийг харуулна:

Ангилал	Түрээслэгч	Үйлчилгээ үзүүлэгч			Өмчлөгч	
Хэлцлийн нийтлэг төрлүүд	Түрээс (жишээ нь; эзэмшигч нь эрх бүхий этгээдээс хөрөнгийг түрээслэх)	Үйлчилгээ болон засварын гэрээ (тодорхой зорилтууд, жишээлбэл; өрийн цуглуулалт, байгууламж-ийн удирдлага)	Засварлах-ажиллуулах-шилжүүлэх	Барьж байгуулах-ажиллуулах-шилжүүлэх	Барьж байгуулах-өмчлөх-ажиллуул-ах	100% хөрөнгө оруулалтаа татах/ хувьчлах/ Компани байгуулах
Хөрөнгийн өмчлөл	Эрх бүхий этгээд			Эзэмшигч		
Капитал хөрөнгө оруулалт	Эрх бүхий этгээд		Эзэмшигч			
Эрэлтийн эрсдэл	Хувцаалцах	Эрх бүхий этгээд	Эрх бүхий этгээд ба/буюу эзэмшигч		Эзэмшигч	
Нийтлэг хугацаа	8-20 жил	1-5 жил	25-30 жил		Тодорхой бус (эсвэл заавал биелүүлэх хэлцэл буюу түрээсээр хязгаарлаж болно)	
Үлдэх хувь оролцоо	Эрх бүхий этгээд			Эзэмшигч		
Холбогдох УСНББОУС	УСНББОУС 13	УСНББОУС 1	Энэ УСНББОУС/ УСНББОУС 17/ УСНББОУС 31		УСНББОУС 17/ УСНББОУС 31 (үл хүлээн зөвшөөрөлт) УСНББОУС 9 (орлогын хүлээн зөвшөөрөлт)	

## Үлгэрчилсэн жишээ

*Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 32-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

ҮЖ1. Үйлчилгээний концессын хэлцлийн боломжит олон төрлүүдээс зөвхөн гурвыг эдгээр жишээнд авч үзсэн. Эдгээрийн зорилго нь практикт нийтлэг тохиолдох зарим шинжүүдийн нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг үлгэрчлэн харуулах явдал юм. Уг үлгэрчилсэн жишээг аль болох ойлгомжтой болгохын тулд үйлчилгээний концессын хэлцлийн хугацаа ердөө 10 жил бөгөөд тухайн эзэмшигчийн жил тутмын орлого нь тэрхүү хугацааны туршид тогтмол байна гэж төсөөлсөн. Практикт, хугацаа нь илүү урт байж болох бөгөөд жил тутмын орлого нь цаг хугацааны явцад нэмэгдэж болох юм.

### **Хэлцлийн хугацаа (Бүх гурван жишээний хувьд ижил байна)**

ҮЖ2. Эдгээр жишээнд мөнгөн дүнг “тоолох нэгж (ТН)” гэж тэмдэглэсэн.

ҮЖ3. Эдгээр нөхцлүүд нь дараах гурван жишээний хувьд ижил байна.

ҮЖ4. Хэлцлийн нөхцөлд зааснаар, эзэмшигч нь авто замыг хоёр жилийн дотор барьж дуусгах шаардлагатай бөгөөд тогтоосон стандартын дагуу уг авто замд найман жилийн хугацаанд (өөрөөр хэлбэл, 3-10 дахь жилд) засвар үйлчилгээ хийж, ажиллуулна. Хэлцэл нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах бөгөөд тус авто зам нь 9-р параграфт (ашиглалтын нийт хугацааны хөрөнгийн хувьд 10-р параграфт) заасан, үйлчилгээний концессын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх нөхцлүүдийг хангаж байна.

ҮЖ5. Мөн хэлцлийн нөхцөлд зааснаар, авто замын анхны хучилт нь тогтоосон стандартаас муудсан тохиолдолд эзэмшигч нь уг авто замд дахин хучилт хийх шаардлагатай. Эзэмшигч нь 8 дахь жилийн эцэст дахин хучилт хийх шаардлагатай бөгөөд түүний бодит үнэ цэнэ нь 110 ТН байна гэж тооцоолсон. Энэхүү үйлчилгээний төлөө эзэмшигчид олгох нөхөн төлбөрийг урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүд ба/буюу эрх бүхий этгээдээс уг эзэмшигчид олгосон тэрхүү үйлчилгээний концессын хөрөнгө буюу орлого бий болгодог бусад хөрөнгүүдээс орлого олох эзэмшигчийн эрх байдлаар тусгадаг.

ҮЖ6. Авто замын анхны хучилт нь уг үйлчилгээний концессын хөрөнгийн тусдаа бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үйлчилгээний концессын хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед УСНББОУС 17-д заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байсан гэж төсөөлсөн. Түүнчлэн, дахин хучилтыг хийх үед тусдаа бүрэлдэхүүн хэсэг байдлаар хүлээн зөвшөөрөх уг дахин хучилтын ажлын хугацаа ба дүн хангалттай тодорхой гэж төсөөлнө.<sup>3</sup>

---

<sup>3</sup> Хэрэв ийм биш байсан (жишээлбэл; эзэмшигч нь ирээдүйд дахин хучилт хийх эсвэл уг үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд нэмэлт засвар үйлчилгээний зардал гаргах) бол уг бүрэлдэхүүн хэсгийг хүлээн зөвшөөрөх нь тохиромжгүй байж болох юм.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

Дахин хучилтын хүлээгдэж буй өртгийг тухайн үйлчилгээний концессын хөрөнгийн тусдаа бүрэлдэхүүн хэсэг байдлаар хүлээн зөвшөөрөх хучилтын анхны өртгийг тооцоолоход ашиглаж болно гэж үзсэн. Иймээс уг авто замын анхны хучилтыг тухайн үйлчилгээний концессын хөрөнгийн анхны бодит үнэ цэнийн тусдаа бүрэлдэхүүн хэсэг байдлаар хүлээн зөвшөөрч, дахин хучилтын тооцоолсон бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд 3-8 дахь жилийн хугацаанд элэгдүүлнэ. Энэхүү элэгдлийн хугацаа нь авто замын суурийн ашиглалтын хугацаанаас богино бөгөөд дахин хучилтыг 25 жил тутамд биш, харин ихэвчлэн 6 жил тутамд хийдэг гэдгийг харгалзан үзнэ. Барилгын ажлын явцад зөвхөн суурийн хэсгийг 1 дэх жилд барьж дуусгах ба авто зам нь зөвхөн 2 дахь жилийн эцэст ашиглалтанд ороход бэлэн болно гэж төсөөлнө.

- ҮЖ7. 8 жилийн дараа уг үйлчилгээний концессын хөрөнгийн тусдаа бүрэлдэхүүн хэсэг байдлаар тэрхүү авто замын сольж орлуулсан бүрэлдэхүүн хэсгийг хүлээн зөвшөөрөх нь мөн тухайн эрх бүхий этгээдийн хүлээн зөвшөөрөх өр төлбөрийг нэмэгдүүлэх үр дүнтэй байна. Уг өр төлбөр нь эзэмшигчид эрх олгох загвартай холбоотой байх тохиолдолд энэхүү нэмэгдэлтэнд хамаарах орлогыг тухайн хэлцлийн хугацааны туршид жигд хүлээн зөвшөөрнө. Гэвч зарлага нь анхны үйлчилгээний чадавхийг хэвээр хадгалах биш, харин замын шинэ эгнээ гэх мэт үйлчилгээний чадвахи боломжийн сайжралтыг илэрхийлж байвал тэрхүү сайжруулалттай холбоотой орлогыг зөвхөн уг үйл явдал гарч тохиолдсон үед хүлээн зөвшөөрөх нь тохиромжтой байна.
- ҮЖ8. 3 дахь жилийн эхэнд тус авто замын нийт бодит үнэ цэнэ нь 1,050 ТН байсан бөгөөд энэ нь суурийн давхаргын барилгын ажилтай холбоотой 940 ТН, хучилтын давхаргатай холбоотой 110 ТН-ээс бүрдэж байна. Дахин хучилтын (үүнийг УСНББОУС 17-гийн дагуу орлох бүрэлдэхүүн хэсэг гэж үзнэ) бодит үнэ цэнийг тооцоолохын тулд энэхүү хучилтын давхаргын бодит үнэ цэнийг ашиглана. Мөн уг орлох бүрэлдэхүүн хэсгийн 9 ба 10 дахь жилийн элэгдлийг тооцоолохын тулд энэхүү хучилтын давхаргын тооцоолсон ашиглалтын хугацааг (жишээлбэл; 6 жил) ашиглана. Авто замын анхны нийт бодит үнэ цэнэ нь хэрэв хамааралтай бол тухайн хөрөнгөтэй холбоотой урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээс бага байна.
- ҮЖ9. Авто замын суурь нь 25 жилийн эдийн засгийн ашиглалтын хугацаатай. Эрх бүхий этгээд нь шулуун шугамын аргаар жил тутмын элэгдлийг тооцоолдог. Иймээс суурийн давхаргын хувьд жилийн элэгдэл нь 38 ТН (940/25) байна. Хучилтын давхаргыг 6 жилийн хугацаанд (анхны бүрэлдэхүүн хэсгийг 3-8 дахь жилд, орлох бүрэлдэхүүн хэсгийг 9 дэх жилээс эхлэн) элэгдүүлнэ. Хучилтын давхаргатай холбоотой жил тутмын элэгдэл нь 18 ТН (110 ТН/6) байна. Үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд тухайн авто замын үнэ цэнэд бууралт үүсэхгүй.
- ҮЖ10. Эзэмшигчийн капиталын өртгийг тодорхойлох практик боломжгүй юм. Үйлчилгээний концессын хэлцлийн тухайн хөрөнгөнд тусгайлан хамаарах нуугдмал хүүний түвшин нь 6.18 хувь байна.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

- ҮЖ11. Бүх мөнгөн гүйлгээ нь жилийн эцэст үүсдэг гэж төсөөлнө.
- ҮЖ12. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь мэдэгдэхүйц нөлөөгүй гэж үзсэн. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь мэдэгдэхүйц нөлөөтэй байх үед тохиромжтой аргын талаархи заавар удирдамжийг МЗУ59-р параграфт илэрхийлсэн.
- ҮЖ13. 10 дахь жилийн эцэст уг хэлцлийн хугацаа дуусна. Хэлцлийн хугацааны эцэст уг эзэмшигч нь авто замын үйл ажиллагааг эзэмшигчид шилжүүлнэ.
- ҮЖ14. Гурван жишээ тус бүрд тухайн эзэмшигчид олгох нийт нөхөн төлбөр нь үйлчилгээний концессын хэлцлийн бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг тусган оруулсан бөгөөд тэдгээр үйлчилгээ тус бүрийн бодит үнэ цэнийг тусган илэрхийлнэ. Үүнийг доорх Үзүүлэн 1-д харуулав.
- ҮЖ15. Эрх бүхий этгээдийн үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ийм хөрөнгийг УСНББОУС 17-д заасан өртгийн загвар ашиглан хүлээн зөвшөөрнө.

### **Үзүүлэн 1: Хэлцлийн бүрэлдэхүүн хэсгүүдийн бодит үнэ цэнэ (Тоолох Нэгж)**

<b>Гэрээний бүрэлдэхүүн хэсэг</b>	<b>Бодит үнэ цэнэ</b>
Авто зам – суурийн давхарга	940
Авто зам – анхны хучилтын давхарга	110
Авто замын нийт бодит үнэ цэнэ	1,050
Жил тутмын үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг	12
Үр ашигт хүүний хувь	6.18%

### **Жишээ 1: Эрх бүхий этгээд нь урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийг эзэмшигчид төлдөг**

#### *Нэмэлт нөхцөл*

- ҮЖ16. Авто замыг олон нийтэд ашиглуулах боломжтой байхын тулд эрх бүхий этгээд нь 3-10 дахь жилийн хугацаанд жил бүр 200 ТН-ийг эзэмшигчид төлөхийг уг хэлцлийн нөхцлөөр шаарддаг. Нийт төлбөр (3-10 дахь жилийн хугацаанд жил бүр 200 ТН-ийн төлбөр) нь Үзүүлэн 1-д харуулсан, үйлчилгээ нэг бүрийн бодит үнэ цэнийг илэрхийлнэ. Эдгээр төлбөр нь авто замын барилгын өртөг, жил тутмын 12 ТН-ийн үйл ажиллагааны зардал, 8 дахь жилд авто замыг дахин хучих 110 ТН-ийн зардлын хувьд тухайн эзэмшигчид олгох нөхөн олговрыг нөхөхөд зориулагдана.

#### *Санхүүгийн тайлангийн үр нөлөө*

- ҮЖ17. Эрх бүхий этгээд нь уг үйлчилгээний концессын хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр үндсэн хөрөнгө гэж анх хүлээн зөвшөөрнө (нийт 1,050 ТН, энэ нь суурийн давхаргын барилгын ажилтай холбоотой 940 ТН, анхны

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

хучилтын давхаргын ажилтай холбоотой 110 ТН-ээс бүрдэж байна). Тухайн хөрөнгийг барьж байгуулсан хэмжээгээр (1 дэх жилд 525 ТН, 2 дахь жилд мөн 525 ТН) хүлээн зөвшөөрнө. 3 дахь жилээс эхлэн элэгдлийг жил бүр тооцно (56 ТН, энэ нь суурь давхаргын 38 ТН, хучилтын давхаргын 18 ТН-ээс бүрдэнэ).

ҮЖ18. Эрх бүхий этгээд нь баригдаж буй тухайн хөрөнгийн 1 дэх жилийн эцэс дэх бодит үнэ цэнэ (525 ТН)-тэй тэнцүү бодит үнэ цэнээр санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрнө. Нэмэлт барилгын ажлын бодит үнэ цэнэ (525 ТН) ба төлөгдөөгүй санхүүгийн өр төлбөрөөс тооцогдох санхүүгийн зардлын аль алиныг тусгахын тулд 2 дахь жилийн эцэст өр төлбөрийн дүнг нэмэгдүүлнэ. Үйлчилгээний концессын хэлцлийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой урьдчилан тодорхойлсон төлбөрийн дүн мэдэгдэж байгаа учраас эрх бүхий этгээд нь уг өр төлбөрийг бууруулах төлбөрийн дүнг тодорхойлж чадах юм. 6.18 хувийн нуугдмал хүүний түвшнээр тооцоолсон санхүүгийн зардлыг жил бүр хүлээн зөвшөөрнө. Дараагийн тайлант үед өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр, өөрөөр хэлбэл анхны хүлээн зөвшөөрсөн дүн дээр тэрхүү дүнгээс үр ашигт хүүний арга ашиглан тооцоолсон санхүүгийн зардлыг нэмж, буцаан төлөлтийг хассан дүнгээр хэмжинэ.

ҮЖ19. Авто замын дахин хучилтын нөхөн төлбөрийг тэдгээр урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдэд тусган оруулдаг. Авто замын дахин хучилттай холбоотой мөнгөн гүйлгээний шууд үр нөлөө байхгүй; гэвч эрх бүхий этгээд нь хучилтын ажил хийгдсэн үед түүнийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд 9 дэх жилээс эхлэн 110 ТН/6=18 ТН-ийн элэгдлийн зардлыг хүлээн зөвшөөрнө.

ҮЖ20. Авто замын засвар үйлчилгээ болон үйл ажиллагааны нөхөн төлбөрийг (12 ТН-ийг) тэдгээр урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдэд тусган оруулдаг. Энэхүү үйлчилгээний зардалтай холбоотой мөнгөн гүйлгээний шууд үр нөлөө байхгүй; гэвч эрх бүхий этгээд нь уг зардлыг жил бүр хүлээн зөвшөөрнө.

ҮЖ21. Үйлчилгээний зардлыг УСНББОУС 1-ийн дагуу тайлагнана.

*Мөнгөн гүйлгээний төлөв байдал, Санхүүгийн үр дүнгийн тайлан, Санхүүгийн байдлын тайлан*

ҮЖ22. Тухайн хэлцлийн хугацааны турш дахь эрх бүхий этгээдийн мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайлан, санхүүгийн байдлын тайланг Хүснэгт 1.1-1.3-д үлгэрчлэн харуулав. Мөн санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлтийг Хүснэгт 1.4-д харуулсан.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

**Хүснэгт 1.1 Мөнгөн гүйлгээ (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10	Дүн
Урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүд	-	-	(200)	(200)	(200)	(200)	(200)	(200)	(200)	(200)	(1,600)
Цэвэр мөнгөн орлого/(зарлага)	-	-	(200)	(200)	(200)	(200)	(200)	(200)	(200)	(200)	(1,600)

**Хүснэгт 1.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10	Дүн
Үйлчилгээний зардал	-	-	(12)	(12)	(12)	(12)	(12)	(12)	(12)	(12)	(96)
Санхүүгийн зардал	-	(32)	(67)	(59)	(51)	(43)	(34)	(25)	(22)	(11)	(344)
Элэгдэл-суурийн давхарга	-	-	(38)	(38)	(38)	(38)	(38)	(38)	(38)	(38)	(304)
Элэгдэл-анхны хучилтын давхарга	-	-	(18)	(19)	(18)	(18)	(19)	(18)	-	-	(110)
Элэгдэл-орлох хучилтын давхарга	-	-	-	-	-	-	-	-	(18)	(19)	(37)
Нийт элэгдэл	-	-	(56)	(57)	(56)	(56)	(57)	(56)	(56)	(57)	(451)
Жилийн ашиг/алдагдал	-	(32)	(135)	(128)	(119)	(111)	(103)	(93)	(90)	(80)	(891)

**ЖИЧ:**

- 3-8 дахь жилийн элэгдэл нь уг авто замын анхны барьсан хучилтын элэгдлийг илэрхийлнэ. Үүнийг тэрхүү хугацаанд бүрэн элэгдүүлнэ. 9-10 дахь жилийн элэгдэл нь 8 дахь жилд хүлээн зөвшөөрсөн уг үйлчилгээний концессын хөрөнгийн шинэ бүрэлдэхүүн хэсгийн (хучилтын) элэгдлийг илэрхийлнэ.
- Энэ үлгэрчилсэн жишээнд элэгдлийн шулуун шугамын аргыг ашигласан боловч уг аргыг бүх тохиолдолд ашиглах зорилгогүй юм. “Элэгдлийн арга нь тухайн байгууллага уг хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг ашиглан зарцуулахаар хүлээгдэж буй хэв загварыг тусгана” гэж УСНББОУС 17-гийн 76-р параграфт заасан байдаг. Үүнтэй адилаар, биет бус хөрөнгийн хувьд УСНББОУС 31-ийн 96-р параграфт “Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна” гэж заасан.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

**Хүснэгт 1.3 Санхүүгийн байдлын тайлан (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10
Үйлчилгээний концессын хөрөнгө-суурийн давхарга	525	940	902	864	826	788	750	712	674	636
Үйлчилгээний концессын хөрөнгө-анхны хучилтын давхарга	-	110	92	73	55	37	18	-	-	-
Үйлчилгээний концессын хөрөнгө-орлох хучилтын давхарга	-	-	-	-	-	-	-	110	92	73
Нийт үйлчилгээний концессын хөрөнгө	525	1,050	994	937	881	825	768	822	766	709
Мөнгө	-	-	(200)	(400)	(600)	(800)	(1,000)	(1,200)	(1,400)	(1,600)
Санхүүгийн өр төлбөр	(525)	(1,082)	(961)	(832)	(695)	(550)	(396)	(343)	(177)	-
Хуримтлагдсан ашиг/алдагдал	-	32	167	295	414	525	628	721	811	891

**ЖИЧ:**

1. Энэ жишээнд, уг авто замын анхны барьсан хучилт бүрэн элэгдсэн үе буюу 8 дахь жилд хүлээгдэж байгаачлан, дахин хучилтыг хийнэ. Хэрэв дахин хучилтыг үүнээс эрт хийвэл уг авто замын анхны барьсан хучилт бүрэн элэгдэхгүй бөгөөд дахин хучилттай холбоотой тухайн үйлчилгээний концессын хөрөнгийн шинэ бүрэлдэхүүн хэсгийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө тэрхүү элэгдээгүй үлдсэн хэсгийг УСНББОУС 17-гийн дагуу үл хүлээн зөвшөөрнө.
2. Дахин хучилттай холбоотой уг үйлчилгээний концессын хөрөнгийн шинэ бүрэлдэхүүн хэсгийг 8 дахь жилд хүлээн зөвшөөрнө. Энэхүү нэмэлт бүрэлдэхүүн хэсгийн элэгдлийг 9-10 дахь жилд тусгана (Хүснэгт 1.2).
3. Үйлчилгээний концессын хөрөнгийн уг шинэ бүрэлдэхүүн хэсгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд санхүүгийн өр төлбөрийг 8 дахь жилд нэмэгдүүлнэ.



**Хүснэгт 1.4 Санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10
Эхний үлдэгдэл	-	525	1,082	961	832	695	550	396	343	177
Үйлчилгээний концессын анхны хөрөнгийн хамт хүлээн зөвшөөрсөн өр төлбөр	525	525	-	-	-	-	-	-	-	-
Төлбөр хийгдэхийн өмнө өр төлбөр дээр нэмэгдэх санхүүгийн зардал	-	32	-	-	-	-	-	-	-	-
Өр төлбөрийг бууруулах тэдгээр урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийн хэсэг	-	-	(121)	(129)	(137)	(145)	(154)	(163)	(166)	(177)
Орлуулсан хучилтын давхаргын хамт хүлээн зөвшөөрсөн өр төлбөр	-	-	-	-	-	-	-	110	-	-
Эцсийн үлдэгдэл	525	1,082	961	832	695	550	396	343	177	-

**Жишээ 2: Эрх бүхий этгээд нь авто замын ашиглалтын хувьд хэрэглэгчдээс хураамж авах эрхийг эзэмшигчид олгодог**

*Хэлцлийн нэмэлт нөхцөл*

ҮЖ23. Эзэмшигч нь авто замыг ашиглах жолооч нараас хураамж авах эрхийг уг хэлцлийн нөхцлөөр түүнд олгодог. Эзэмшигч нь тухайн хэлцлийн хугацаанд тээврийн хэрэгслийн тоо тогтмол байх бөгөөд 3-10 дахь жил тус бүр 200 ТН-ийн хураамж авна гэж таамагласан. Нийт төлбөр (3-10 дахь жилийн хугацаанд жил бүр 200 ТН-ийн хураамж) нь Үзүүлэн 1-д харуулсан, үйлчилгээ нэг бүрийн бодит үнэ цэнийг илэрхийлэх бөгөөд энэ нь авто замын барилгын өртөг, жил тутмын 12 ТН-ийн үйл ажиллагааны зардал, 8 дахь жилд авто замыг дахин хучих 110 ТН-ийн зардлын хувьд тухайн эзэмшигчид олгох нөхөн олговрыг нөхөхөд зориулагдана.

*Санхүүгийн тайлангийн үр нөлөө*

- ҮЖ24. Эрх бүхий этгээд нь уг үйлчилгээний концессын хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр үндсэн хөрөнгө гэж анх хүлээн зөвшөөрнө (нийт 1,050 ТН, энэ нь суурийн давхаргын барилгын ажилтай холбоотой 940 ТН, анхны хучилтын давхаргын ажилтай холбоотой 110 ТН-ээс бүрдэж байна). Тухайн хөрөнгийг барьж байгуулсан хэмжээгээр (1 дэх жилд 525 ТН, 2 дахь жилд мөн 525 ТН) хүлээн зөвшөөрнө. 3 дахь жилээс эхлэн элэгдлийг жил бүр тооцно (56 ТН, энэ нь суурь давхаргын 38 ТН, хучилтын давхаргын 18 ТН-ээс бүрдэнэ).
- ҮЖ25. Эрх бүхий этгээд нь 3-10 дахь жилд 200 ТН-ийн хураамж авах эрхийг эзэмшигчид олгосны хариуд эзэмшигчид эрх олгох загварын дагуу өр төлбөрийг тухайн үйлчилгээний концессын хөрөнгийн төлбөр болгон хүлээн зөвшөөрнө. Тэрхүү хөрөнгийг хүлээн зөвшөөрснөөр өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.
- ҮЖ26. Үйлчилгээний концессын хөрөнгө ашиглах эрхийг тухайн хөрөнгө нь эдийн засгийн үр өгөөж бий болгох боломжтой болсон үеэс эхлэн тэрхүү үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд жигд ашиглахаар хүлээгдэж буй учраас эрх бүхий этгээд нь орлогыг ийм байдлаар хүлээн зөвшөөрөх ба өр төлбөрийг 3-10 дахь жилийн хугацаанд мөн бууруулна.
- ҮЖ27. Эзэмшигч нь тухайн үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд олохоор хүлээгдэж буй хураамжид тэрхүү авто замын дахин хучилтын нөхөн төлбөрийг тусган оруулдаг. Авто замын дахин хучилттай холбоотой мөнгөн гүйлгээний шууд үр нөлөө байхгүй; гэвч эрх бүхий этгээд нь хучилтын ажил хийгдсэн үед түүнийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд 9 дэх жилээс эхлэн  $110 \text{ ТН} / 6 = 18 \text{ ТН}$ -ийн элэгдлийн зардлыг хүлээн зөвшөөрнө.
- ҮЖ28. Авто замын засвар үйлчилгээ болон үйл ажиллагааны нөхөн төлбөрийг (12 ТН-ийг) тухайн үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд олохоор хүлээгдэж буй хураамжид тусган оруулдаг. Энэхүү үйлчилгээний зардалтай холбоотой мөнгөн гүйлгээний шууд үр нөлөө байхгүй. Эрх бүхий этгээд нь мөнгөн зарлага гаргахгүй учраас энэ нь түүний мөнгөн гүйлгээнд нөлөөлөхгүй. Анх хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь тухайн эзэмшигчийн гаргаж болох аливаа үйлчилгээний зардлыг агуулаагүй байдаг учраас үүнийг үйл ажиллагааны зардал гэж хүлээн зөвшөөрөхгүй.

*Мөнгөн гүйлгээний төлөв байдал, Санхүүгийн үр дүнгийн тайлан, Санхүүгийн байдлын тайлан*

- ҮЖ29. Тухайн хэлцлийн хугацааны турш дахь эрх бүхий этгээдийн мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайлан, санхүүгийн байдлын тайланг Хүснэгт 2.1-2.3-д үлгэрчлэн харуулав. Мөн өр төлбөрийн өөрчлөлтийг Хүснэгт 2.4-д харуулсан.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

**Мөнгөн гүйлгээ**

ҮЖ30. Эзэмшигчид төлсөн төлбөр байхгүй учраас энэ жишээний хувьд мөнгөн гүйлгээний үр нөлөөгүй байна.

**Хүснэгт 2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10	Дүн
Орлого (өр төлбөрийн бууралт)	-	-	145	145	145	145	145	145	145	145	1,160
Элэгдэл-суурийн давхарга	-	-	(38)	(38)	(38)	(38)	(38)	(38)	(38)	(38)	(304)
Элэгдэл-анхны хучилтын давхарга	-	-	(18)	(19)	(18)	(18)	(19)	(18)	-	-	(110)
Элэгдэл-орлох хучилтын давхарга	-	-	-	-	-	-	-	-	(18)	(19)	(37)
Нийт элэгдэл	-	-	(56)	(57)	(56)	(56)	(57)	(56)	(56)	(57)	(451)
Жилийн ашиг/алдагдал	-	-	89	88	89	89	88	89	89	88	709

**ЖИЧ:**

- 3-8 дахь жилийн элэгдэл нь уг авто замын анхны барьсан хучилтын элэгдлийг илэрхийлнэ. Үүнийг тэрхүү хугацаанд бүрэн элэгдүүлнэ.
- 9-10 дахь жилийн элэгдэл нь 8 дахь жилд хүлээн зөвшөөрсөн уг үйлчилгээний концессын хөрөнгийн шинэ бүрэлдэхүүн хэсгийн (хучилтын) элэгдлийг илэрхийлнэ.
- Орлого (өр төлбөрийн бууралт) нь уг нэмэлт өр төлбөрөөс үүсэх орлогыг агуулсан байна (Хүснэгт 2.3).
- Бүх орлогыг тухайн хэлцлийн хугацааны туршид жигд хүлээн зөвшөөрнө.

**Хүснэгт 2.3 Санхүүгийн байдлын тайлан (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10
Үйлчилгээний концессын хөрөнгө-суурийн давхарга	525	940	902	864	826	788	750	712	674	636
Үйлчилгээний концессын хөрөнгө-анхны хучилтын давхарга	-	110	92	73	55	37	18	-	-	-
Үйлчилгээний концессын хөрөнгө-орлох хучилтын давхарга	-	-	-	-	-	-	-	110	92	73
Нийт үйлчилгээний концессын хөрөнгө	525	1,050	994	937	881	825	768	822	766	709
Мөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-
Өр төлбөр	(525)	(1,050)	(905)	(760)	(615)	(470)	(325)	(290)	(145)	-
Хуримтлагдсан ашиг/алдагдал	-	-	(89)	(177)	(266)	(355)	(443)	(532)	(621)	(709)

**ЖИЧ:**

1. Энэ жишээнд, уг авто замын анхны барьсан хучилт бүрэн элэгдсэн үе буюу 8 дахь жилд хүлээгдэж байгаачлан, дахин хучилтыг хийнэ. Хэрэв дахин хучилтыг үүнээс эрт хийвэл уг авто замын анхны барьсан хучилт бүрэн элэгдэхгүй бөгөөд дахин хучилттай холбоотой тухайн үйлчилгээний концессын хөрөнгийн шинэ бүрэлдэхүүн хэсгийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө тэрхүү элэгдээгүй үлдсэн хэсгийг УСНББОУС 17-гийн дагуу үл хүлээн зөвшөөрнө.
2. Дахин хучилттай холбоотой уг үйлчилгээний концессын хөрөнгийн шинэ бүрэлдэхүүн хэсгийг 8 дахь жилд хүлээн зөвшөөрнө. Энэхүү нэмэлт бүрэлдэхүүн хэсгийн элэгдлийг 9-10 дахь жилд тусгана (Хүснэгт 2.2).
3. Үйлчилгээний концессын хөрөнгийн уг шинэ бүрэлдэхүүн хэсгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд өр төлбөрийг 8 дахь жилд нэмэгдүүлнэ.

**Хүснэгт 2.4 Өр төлбөрийн өөрчлөлт (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10
Эхний үлдэгдэл	-	525	1,050	905	760	615	470	325	290	145
Үйлчилгээний концессын анхны хөрөнгийн хамт хүлээн зөвшөөрсөн өр төлбөр	525	525	-	-	-	-	-	-	-	-
Орлого (өр төлбөрийн бууралт)	-	-	(145)	(145)	(145)	(145)	(145)	(145)	(145)	(145)
Орлуулсан хучилтын давхаргын хамт хүлээн зөвшөөрсөн өр төлбөр	-	-	-	-	-	-	-	110	-	-
Эцсийн үлдэгдэл	525	1,050	905	760	615	470	325	290	145	-

**Жишээ 3: Эрх бүхий этгээд нь урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийг эзэмшигчид төлдөг ба авто замын ашиглалтын хувьд хэрэглэгчдээс хураамж авах эрхийг эзэмшигчид мөн олгодог**

*Хэлцлийн нэмэлт нөхцөл*

ҮЖ31. Эзэмшигч нь авто замыг ашиглах жолооч нараас хураамж авах эрхийг уг хэлцлийн нөхцлөөр түүнд олгодог. Эзэмшигч нь тухайн хэлцлийн хугацаанд тээврийн хэрэгслийн тоо тогтмол байх бөгөөд 3-10 дахь жил тус бүр 100 ТН-ийн хураамж авна гэж таамагласан. Мөн эрх бүхий этгээд нь жил бүр 100 ТН-ийн урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийг эзэмшигчид төлөхийг уг хэлцлийн нөхцлөөр шаарддаг. Хураамж авах эрхийн бодит үнэ цэнэ болон урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүд нь тухайн эзэмшигчид тэнцүү хэмжээгээр (өөрөөр хэлбэл, эзэмшигчид олгох нөхөн төлбөрийн хэлбэр тус бүрээс 50 хувийн) нөхөн төлбөр олгоно гэж үзсэн.

*Санхүүгийн тайлангийн үр нөлөө*

ҮЖ32. Эрх бүхий этгээд нь уг үйлчилгээний концессын хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр үндсэн хөрөнгө гэж анх хүлээн зөвшөөрнө (нийт 1,050 ТН, энэ нь суурийн давхаргын барилгын ажилтай холбоотой 940 ТН, анхны хучилтын давхаргын ажилтай холбоотой 110 ТН-ээс бүрдэж байна). Тухайн хөрөнгийг барьж байгуулсан хэмжээгээр (1 дэх жилд 525 ТН, 2 дахь жилд мөн 525 ТН) хүлээн зөвшөөрнө. Элэгдлийг жил бүр тооцно (56 ТН, энэ нь суурь давхаргын 38 ТН, хучилтын давхаргын 18 ТН-ээс бүрдэнэ).

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

- ҮЖ33. Эрх бүхий этгээд нь 3-10 дахь жилд 100 ТН-ийн хураамж авах эрхийг эзэмшигчид олгосны хариуд эзэмшигчид эрх олгох загварын дагуу төлөх өр төлбөр ба 3-10 дахь жилд 100 ТН-ийг төлөх санхүүгийн өр төлбөрийн аль алиныг тухайн үйлчилгээний концессын хөрөнгийн төлбөр болгон хүлээн зөвшөөрнө. 1 дэх жилийн эцэст хөрөнгийг (525 ТН-ийг) хүлээн зөвшөөрснөөр уг өр төлбөр болон санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Нэмэлт барилгын ажлын бодит үнэ цэнэ (525 ТН) ба төлөгдөөгүй санхүүгийн өр төлбөрөөс тооцогдох санхүүгийн зардлын аль алиныг тусгахын тулд 2 дахь жилийн эцэст тэдгээр өр төлбөр болон санхүүгийн өр төлбөрийн дүнг нэмэгдүүлнэ.
- ҮЖ34. Эзэмшигчид олгосон хураамж авах эрх болон урьдчилан тодорхойлсон төлбөрүүдтэй холбоотой уг эрх бүхий этгээдийн үүргийг хоёр тусдаа зүйлс гэж үздэг. Иймээс энэ хэлцлийн хувьд, эзэмшигчид олгох тухайн эрх бүхий этгээдийн нөхөн төлбөрийг өр төлбөр ба санхүүгийн өр төлбөр гэсэн хоёр хэсэгт хуваах шаардлагатай.
- ҮЖ35. Тухайн хөрөнгө нь үйлчилгээний үр өгөөж бий болгох боломжтой болсон үеэс эхлэн хураамжийг тэрхүү үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд жигд олохоор хүлээгдэж буй учраас эрх бүхий этгээд нь орлогыг ийм байдлаар хүлээн зөвшөөрөх ба 525 ТН-ийн (1 ба 2 дахь жилийн эцэст жигд хүлээн зөвшөөрсөн) өр төлбөрийг 3-10 дахь жилийн хугацаанд бууруулна.
- ҮЖ36. Эрх бүхий этгээд нь 1 ба 2 дахь жилийн эцэст жигд хүлээн зөвшөөрсөн, тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийн тэн хагастай (525 ТН-тэй) тэнцүү бодит үнэ цэнээр санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрнө; эзэмшигчид эрх олгох загварын дагуу өр төлбөрийг тэрхүү хөрөнгийн бодит үнэ цэнийн үлдсэн тэн хагастай тэнцүү дүнгээр хүлээн зөвшөөрнө. Төлөгдөөгүй санхүүгийн өр төлбөрөөс тооцогдох санхүүгийн зардлын дүнгээр 2 дахь жилийн эцэст уг санхүүгийн өр төлбөрийг бас нэмэгдүүлнэ. Үйлчилгээний концессын хэлцлийн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой урьдчилан тодорхойлсон төлбөрүүдийн дүн мэдэгдэж байгаа учраас эрх бүхий этгээд нь уг өр төлбөрийг бууруулах төлбөрийн дүнг тодорхойлж чадах юм. 6.18 хувийн нуугдмал хүүний түвшнээр тооцоолсон санхүүгийн зардлыг жил бүр хүлээн зөвшөөрнө. Дараагийн тайлант үед өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр, өөрөөр хэлбэл анхны хүлээн зөвшөөрсөн дүн дээр тэрхүү дүнгээс үр ашигт хүүний арга ашиглан тооцоолсон санхүүгийн зардлыг нэмж, буцаан төлөлтийг хассан дүнгээр хэмжинэ.
- ҮЖ37. Үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд эзэмшигчийн олохоор хүлээгдэж буй хураамж ба урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдээр уг авто замын дахин хучилтын хувьд нөхөн төлбөрийг (110 ТН-ийг) тэнцүү хэмжээгээр (өөрөөр хэлбэл, тус бүр 50 хувиар) олгодог. Авто замын дахин хучилттай холбоотой мөнгөн гүйлгээний шууд үр нөлөө байхгүй; гэвч эрх бүхий этгээд нь хучилтын ажил хийгдсэн үед түүнийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд 9 дэх жилээс эхлэн  $110 \text{ ТН} / 6 = 18$  ТН-ийн элэгдлийн зардлыг хүлээн зөвшөөрнө.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

- ҮЖ38. Үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд эзэмшигчийн олохоор хүлээгдэж буй хураамж ба урьдчилан тодорхойлсон төлбөрөөр уг авто замын засвар үйлчилгээ болон үйл ажиллагааны хувьд нөхөн төлбөрийг (12 ТН-ийг) тэнцүү хэмжээгээр (өөрөөр хэлбэл, тус бүр 50 хувиар) олгодог. Эрх бүхий этгээд нь мөнгөн зарлага гаргахгүй учраас энэхүү үйлчилгээний зардалтай холбоотой мөнгөн гүйлгээний шууд үр нөлөө байхгүй. Гэвч эрх бүхий этгээд нь урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдтэй холбоотой нөхөн төлбөрийн хэсгийн хувьд зардлыг (6 ТН-ийг) жил бүр хүлээн зөвшөөрнө. Энэхүү үйлчилгээний үлдэх 6 ТН-ийн зардлын хувьд санхүүгийн тайлангийн үр нөлөө байхгүй. Анх хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь тухайн эзэмшигчийн гаргаж болох аливаа үйлчилгээний зардлыг агуулаагүй байдаг учраас үүнийг үйл ажиллагааны зардал гэж хүлээн зөвшөөрөхгүй.
- ҮЖ39. Тухайн хэлцлийн хугацааны турш дахь эрх бүхий этгээдийн мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайлан, санхүүгийн байдлын тайланг Хүснэгт 3.1-3.3-д үлгэрчлэн харуулав. Мөн өр төлбөрийн өөрчлөлтийг Хүснэгт 3.4, санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлтийг Хүснэгт 3.5-д харуулсан.

*Мөнгөн гүйлгээний төлөв байдал, Санхүүгийн үр дүнгийн тайлан, Санхүүгийн байдлын тайлан*

**Хүснэгт 3.1 Мөнгөн гүйлгээ (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10	Дүн
Урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүд	-	-	(100)	(100)	(100)	(100)	(100)	(100)	(100)	(100)	(800)
Цэвэр мөнгөн орлого/(зарлага)	-	-	(100)	(100)	(100)	(100)	(100)	(100)	(100)	(100)	(800)

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

**Хүснэгт 3.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10	Дүн
Орлого (өр төлбөрийн бууралт)	-	-	73	72	73	72	73	72	73	72	580
Үйлчилгээний зардал	-	-	(6)	(6)	(6)	(6)	(6)	(6)	(6)	(6)	(48)
Санхүүгийн зардал	-	(16)	(33)	(30)	(26)	(22)	(17)	(12)	(11)	(5)	(172)
Элэгдэл-суурийн давхарга	-	-	(38)	(38)	(38)	(38)	(38)	(38)	(38)	(38)	(304)
Элэгдэл-анхны хучилтын давхарга	-	-	(18)	(19)	(18)	(18)	(19)	(18)	-	-	(110)
Элэгдэл-орлох хучилтын давхарга	-	-	-	-	-	-	-	-	(18)	(19)	(37)
Нийт элэгдэл	-	-	(56)	(57)	(56)	(56)	(57)	(56)	(56)	(57)	(451)
Жилийн ашиг/алдагдал	-	(16)	(22)	(21)	(15)	(12)	(7)	(2)	-	4	(91)
<b>ЖИЧ:</b>											
<ol style="list-style-type: none"> <li>3-8 дахь жилийн элэгдэл нь уг авто замын анхны барьсан хучилтын элэгдлийг илэрхийлнэ. Үүнийг тэрхүү хугацаанд бүрэн элэгдүүлнэ.</li> <li>9-10 дахь жилийн элэгдэл нь 8 дахь жилд хүлээн зөвшөөрсөн уг үйлчилгээний концессын хөрөнгийн шинэ бүрэлдэхүүн хэсгийн (хучилтын) элэгдлийг илэрхийлнэ.</li> <li>Орлого (өр төлбөрийн бууралт) нь уг нэмэлт өр төлбөрөөс үүсэх орлогыг агуулсан байна (Хүснэгт 3.3).</li> <li>Бүх орлогыг тухайн хэлцлийн хугацааны туршид жигд хүлээн зөвшөөрнө.</li> </ol>											



**Хүснэгт 3.3 Санхүүгийн байдлын тайлан (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10
Үйлчилгээний концессын хөрөнгө-суурийн давхарга	525	940	902	864	826	788	750	712	674	636
Үйлчилгээний концессын хөрөнгө-анхны хучилтын давхарга	-	110	92	73	55	37	18	-	-	-
Үйлчилгээний концессын хөрөнгө-орлох хучилтын давхарга	-	-	-	-	-	-	-	110	92	73
Нийт үйлчилгээний концессын хөрөнгө	525	1,050	994	937	881	825	768	822	766	709
Мөнгө	-	-	(100)	(200)	(300)	(400)	(500)	(600)	(700)	(800)
Өр төлбөр	(262)	(525)	(452)	(380)	(307)	(235)	(162)	(145)	(72)	-
Санхүүгийн өр төлбөр	(263)	(541)	(480)	(416)	(348)	(276)	(199)	(172)	(89)	-
Хуримтлагдсан ашиг/алдагдал	-	16	38	59	74	86	93	95	95	91

**ЖИЧ:**

1. Энэ жишээнд, уг авто замын анхны барьсан хучилт бүрэн элэгдсэн үе буюу 8 дахь жилд хүлээгдэж байгаачлан, дахин хучилтыг хийнэ. Хэрэв дахин хучилтыг үүнээс эрт хийвэл уг авто замын анхны барьсан хучилт бүрэн элэгдэхгүй бөгөөд дахин хучилттай холбоотой тухайн үйлчилгээний концессын хөрөнгийн шинэ бүрэлдэхүүн хэсгийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө тэрхүү элэгдээгүй үлдсэн хэсгийг УСНББОУС 17-гийн дагуу үл хүлээн зөвшөөрнө.
2. Дахин хучилттай холбоотой уг үйлчилгээний концессын хөрөнгийн шинэ бүрэлдэхүүн хэсгийг 8 дахь жилд хүлээн зөвшөөрнө. Энэхүү нэмэлт бүрэлдэхүүн хэсгийн элэгдлийг 9-10 дахь жилд тусгана (Хүснэгт 3.2).
3. Үйлчилгээний концессын хөрөнгийн уг шинэ бүрэлдэхүүн хэсгийн 50 хувийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд өр төлбөрийг 8 дахь жилд нэмэгдүүлнэ.
4. Үйлчилгээний концессын хөрөнгийн уг шинэ бүрэлдэхүүн хэсгийн 50 хувийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд санхүүгийн өр төлбөрийг 8 дахь жилд нэмэгдүүлнэ.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОНЦЕССЫН ХЭЛЦЭЛ: ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

**Хүснэгт 3.4 Өр төлбөрийн өөрчлөлт (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10
Эхний үлдэгдэл	-	262	525	452	380	307	235	162	145	72
Үйлчилгээний концессын анхны хөрөнгийн хамт хүлээн зөвшөөрсөн өр төлбөр	262	263	-	-	-	-	-	-	-	-
Орлого (өр төлбөрийн бууралт)	-	-	(73)	(72)	(73)	(72)	(73)	(72)	(73)	(72)
Орлуулсан хучилтын давхаргын хамт хүлээн зөвшөөрсөн өр төлбөр	-	-	-	-	-	-	-	55	-	-
Эцсийн үлдэгдэл	262	525	452	380	307	235	162	145	72	-

**Хүснэгт 3.5 Санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт (Тоолох нэгж)**

Жил	1	2	3	4	5	6	7	8	9	10
Эхний үлдэгдэл	-	263	541	480	416	348	276	199	172	89
Үйлчилгээний концессын анхны хөрөнгийн хамт хүлээн зөвшөөрсөн өр төлбөр	263	262	-	-	-	-	-	-	-	-
Төлбөр хийгдэхийн өмнө өр төлбөр дээр нэмэгдэх санхүүгийн зардал	-	16	-	-	-	-	-	-	-	-
Өр төлбөрийг бууруулах тэдгээр урьдчилан тодорхойлсон цуврал төлбөрүүдийн хэсэг	-	-	(61)	(64)	(68)	(72)	(77)	(82)	(83)	(89)
Орлуулсан хучилтын давхаргын хамт хүлээн зөвшөөрсөн өр төлбөр	-	-	-	-	-	-	-	55	-	-
Эцсийн үлдэгдэл	263	541	480	416	348	276	199	172	89	-

**УСНББОУС 33-АККРУЭЛ СУУРТ УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ (УСНББОУС)-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ**

**УСНББОУС-ын түүх**

*Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.*

УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-ийг 2015 оны 01 дүгээр сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 33-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)

**УСНББОУС 33-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт**

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
7	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
8	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
36	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
39	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
62А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
62Б	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
62В	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
86	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
102	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
104	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
105	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
106	Хассан	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар

АККРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

107	Хассан	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
129	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
130	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
132	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
154А	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
154Б	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
154В	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар

2015 оны 01 дүгээр сар

## УСНББОУС 33–АККРУЭЛ СУУРТ УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ (УСНББОУС)-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

### АГУУЛГА

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-8
Тодорхойлолт	9-14
УСНББОУС-ыг мөрдсөн өдөр	10
УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан	11
Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь	12
Шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан	13-14
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	15-22
УСНББОУС-д нийцсэн эхлэлийн санхүүгийн байдлын тайлан	15
Нягтлан бодох бүртгэлийн бодлого	16-22
УСНББОУС-ыг буцаах горимоор мөрдөлтийн гажих нөхцлүүд	23-26
Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцэлт	27-32
Шилжилтийн үед үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх чөлөөлөх нөхцлүүд	33-62
Хөрөнгө ба/буюу өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн хувьд чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацаа	36-62
Мөрдөх хугацаанд үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй чөлөөлөх нөхцлүүд	63-134
Хөрөнгө ба/буюу өр төлбөрийг хэмжихэд төсөөлөн тооцсон өртөг ашиглах	64-70
Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг хэмжихэд төсөөлөн тооцсон өртөг ашиглах	71
Хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах (УСНББОУС 34)	72-73
Төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлж болох өдөр	74-76
УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Толилуулга	77-84
УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө	85-87
УСНББОУС 5, Зээлийн Өртөг	88-90
УСНББОУС 10, Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал	91-94
УСНББОУС 13, Түрээс	95-96
УСНББОУС 18, Сегментийн Тайлагнал	97
УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт	98-100
УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж	101-107

АККРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт	108-110
УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга	111-112
УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт	113-122
УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга	123-124
УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө	125-126
УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл	127-128
УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан, УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан, УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт	129-130
УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан	131
УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр	132-134
Тодруулга	135-152
УСНББОУС-д шилжсэн талаархи тайлбар	141
Тохируулгын тайлан	142-147
Бараа материал, Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, Үндсэн хөрөнгө, Биет бус хөрөнгө, Санхүүгийн хэрэглүүр, Үйлчилгээний концессын хөрөнгөнд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах үед хийх тодруулга	148
Хяналтанд буй байгууллага, Хамтарсан үйлдвэр буюу Хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах үед хийх тодруулга	149-150
Шилжилтийн үед УСНББОУС-ын тодруулгын шаардлагуудаас чөлөөлөх	151-152
Шилжилтийн нөхцөл	153
Хүчин төгөлдөр болох хугацаа	154
Хавсралт А: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийг 1-154-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 33-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь аккрузл суурьт УСНББОУС-ыг мөрдсөнөөр санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг, УСНББОУС-ыг анх удаа мөрдөж буй байгууллага дараах өндөр чанартай мэдээллийг толилуулахад зориулсан заавар удирдамжаар хангах явдал юм:
  - (а) Анх удаа мөрдөж буй байгууллагын аккрузл суурьт УСНББОУС-д шилжилтийн талаар ил тод ойлгомжтой тайлагналаар хангах;
  - (б) Анх удаа мөрдөж буй байгууллага нь уг мөрдсөн өдрөөс өмнө ашиглаж байсан нягтлан бодох бүртгэлийн сууриас үл хамааран аккрузл суурьт УСНББОУС-ын дагуу тайлагнах зохих эхлэлийн цэгийг бүрдүүлэх;
  - (в) Үр өгөөж нь өртөг зардлаас илүү байхаар хүлээгдэж байх.

## Цар хүрээ

2. **Аккрузл суурьт УСНББОУС-ыг мөрдөх болон аккрузл суурьт УСНББОУС-д шилжих явцад өөрийн жилийн санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулахдаа байгууллага нь энэхүү УСНББОУС-ыг дагаж мөрдөнө.**
3. Байгууллага нь аккрузл суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдөх үед болон энэ УСНББОУС-аар зөвшөөрсөн шилжилтийн хугацаанд энэхүү УСНББОУС-ыг мөрдөнө. Анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайлбал, дараах тохиолдолд энэ Стандартыг мөрдөхгүй:
  - (а) Тогтоосон шаардлагуудын дагуу өмнө нь толилуулдаг байсан санхүүгийн тайланг, түүнчлэн аккрузл суурьт УСНББОУС-тай нийцсэн талаархи бүрэн тодорхой мэдэгдлийг агуулсан өөр нэг иж бүрэн санхүүгийн тайланг уг тогтоосон шаардлагуудын дагуу толилуулахаа зогсоосон;
  - (б) Өмнөх тайлант үед санхүүгийн тайланг тогтоосон шаардлагуудын дагуу толилуулсан бөгөөд аккрузл суурьт УСНББОУС-тай нийцсэн талаархи бүрэн тодорхой мэдэгдлийг тэдгээр санхүүгийн тайланг агуулсан; эсвэл
  - (в) Хэдийгээр аудитор тэдгээр санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн боловч аккрузл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэсэн бүрэн тодорхой мэдэгдэл бүхий санхүүгийн тайланг өмнөх тайлант үед толилуулсан.
4. Анх удаа мөрдөж буй байгууллага нь аккрузл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс болон шилжилтийн хугацаанд энэ Стандартыг мөрдөнө. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулгад нөлөөлж болох шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон заалтуудыг даган мөрдөхийг энэ Стандартаар зөвшөөрдөг. Эдгээр шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон заалтуудыг даган мөрдсөн тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь уг мөрдсөн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд



болон заалтууд, түүнчлэн үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд чиглэгдсэн явц өрнөлийн талаархи мэдээллийг тодруулах шаардлагатай байдаг.

5. Шилжилтийн үеийн эцэст, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-д шаардсанчлан, аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэхийн тулд аккруэл суурьт бусад УСНББОУС-д заасан, хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулга, тодруулгын шаардлагуудыг дагаж мөрдөх ёстой.
6. УСНББОУС-ыг угаасаа мөрддөг байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ УСНББОУС-ыг мөрдөхгүй. Харин ийм өөрчлөлт нь дараах зүйлсэд захирагдана:
  - (а) Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн талаархи УСНББОУС 3, *Нягтлан Бодох бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-нд заасан шаардлагууд; ба
  - (б) Бусад УСНББОУС-д заасан шилжилтийн тусгай шаардлагууд. УСНББОУС-ыг угаасаа мөрддөг байгууллагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөнд л бусад УСНББОУС-ын шилжилтийн нөхцлүүдийг мөрдөнө; энэ Стандартад тусгайлан зааснаас бусад тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллагын УСНББОУС-д шилжилтийн хувьд тэдгээр бусад УСНББОУС-ын шилжилтийн нөхцлүүдийг мөрдөхгүй.
7. [Хассан]
8. [Хассан]

## Тодорхойлолт

9. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**УСНББОУС-ыг мөрдсөн өдөр** гэдэг нь байгууллага аккруэл суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдсөн өдөр, түүнчлэн уг анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн болон шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг, эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг толилуулсан тайлант үеийн эхлэл юм.

**Төсөөлөн тооцсон өртөг** гэдэг нь тогтоосон өдрөөрх худалдан авалтын өртөг эсвэл элэгдэл тооцсон өртгийн хувьд түүний орлуулагч болгон ашигладаг дүнг хэлнэ.

**УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан** гэдэг нь тухайн санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга, түүнчлэн аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид

нөлөөлөхгүй, энэ Стандартад заасан шилжилтийн үеийн нэг буюу хэд хэдэн чөлөөлөх нөхцлүүдийг мөрдсөний үр дүнд байгууллага УСНББОУС-тай нийцсэн талаар бүрэн тодорхой мэдэгдэл гаргаж чадах ба аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн анхны, жилийн санхүүгийн тайлан юм.

Анх удаа мөрдөж буй байгууллага гэдэг нь аккруэл суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдөж байгаа ба шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг, эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг толилуулж буй байгууллага юм.

Эхлэлийн санхүүгийн байдлын тайлан гэдэг нь анх удаа мөрдөж буй байгууллагын УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх санхүүгийн байдлын тайлан юм.

Шилжилтийн үе гэдэг нь анх удаа мөрдөж буй байгууллага аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөхийн өмнө болон УСНББОУС-тай ингэж нийцсэн талаар бүрэн тодорхой мэдэгдэл гаргах боломжтой болохын өмнө энэ Стандартад заасан, шилжилтийн үеийн нэг буюу хэд хэдэн чөлөөлөх нөхцлүүдийг мөрдөх тайлант үе юм.

Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь гэдэг нь анх удаа мөрдөж буй байгууллага аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөхийн яг өмнө ашиглаж байсан нягтлан бодох бүртгэлийн суурь юм.

Шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан гэдэг нь анх удаа мөрдөж буй байгууллага тухайн санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга, түүнчлэн аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөх, энэ Стандартад заасан шилжилтийн үеийн нэг буюу хэд хэдэн чөлөөлөх нөхцлүүдийг мөрдсөний үр дүнд бусад УСНББОУС-тай нийцсэн талаар бүрэн тодорхой мэдэгдлийг гаргаж чадахгүй тохиолдолд энэ УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланг хэлнэ.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

## УСНББОУС-ыг мөрдсөн өдөр

10. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь байгууллага аккруэл суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдсөн өдөр юм. Энэ нь уг анх удаа мөрдөж буй байгууллага аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн болон шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг, эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг толилуулсан тайлант үеийн эхлэл юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх, энэ Стандартад заасан чөлөөлөх нөхцлүүдийн (36-62-р параграфыг үзнэ үү) давуу талыг өөрийн шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг

бэлтгэхдээ ашигласан бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дууссан үед ба/буюу холбогдох зүйлсийг хүлээн зөвшөөрсөн, хэмжсэн ба холбогдох мэдээллийг тухайн санхүүгийн тайланд зохих УСНББОУС-ын дагуу толилуулсан, тодруулсан үед (аль түрүүнд болох өдрөөр) уг байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн талаар бүрэн тодорхой мэдэгдлийг гаргаж болно. Санхүүгийн тайлан нь холбогдох бүх УСНББОУС-ын бүх шаардлагуудтай нийцсэн байхаас бусад тохиолдолд уг санхүүгийн тайланг УСНББОУС-тай нийцсэн гэж илэрхийлж болохгүй.

### **УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан**

11. Байгууллагын УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан нь уг анх удаа мөрдөж буй байгууллага аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн талаар тухайн санхүүгийн тайланд бүрэн тодорхой мэдэгдлийг илэрхийлсэн анхны, жилийн санхүүгийн тайлан юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх энэ Стандартад заасан, чөлөөлөх нөхцлүүдийг (36-62-р параграфыг үзнэ үү) мөрддөггүй бол аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн түүний анхны санхүүгийн тайлан нь мөн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан байна.

### **Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь**

12. Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь нь уг анх удаа мөрдөж буй байгууллага аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөхийн яг өмнө ашиглаж байсан нягтлан бодох бүртгэлийн суурь юм. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь, нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь эсвэл аккруэл суурийн тохируулсан хувилбар болон бусад тодорхойлсон суурь байж болно.

### **Шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан**

13. Байгууллагын шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан нь уг байгууллага аккруэл суурьт УСНББОУС-д шилжсэн ба тухайн санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж илэрхийлэх түүний чадвар боломжид нөлөөлөх энэ Стандартад заасан, зарим чөлөөлөх нөхцлүүдийг мөрдсөн жилийн санхүүгийн тайлан юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх, энэ Стандартад заасан чөлөөлөх нөхцлүүдийг ашигласан (36-62-р параграфыг үзнэ үү) бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу холбогдох зүйлсийг хүлээн зөвшөөрөх, хэмжих буюу холбогдох мэдээллийг зохих УСНББОУС-ын дагуу толилуулах, тодруулах (аль түрүүнд болох өдөр) хүртэл уг байгууллага нь аккруэл суурьт бусад УСНББОУС-тай нийцсэн талаар бүрэн тодорхой мэдэгдлийг хийж болохгүй. Санхүүгийн тайлан нь холбогдох бүх УСНББОУС-ын бүх шаардлагуудтай нийцсэн байхаас бусад тохиолдолд уг санхүүгийн тайланг УСНББОУС-тай нийцсэн гэж илэрхийлж болохгүй.

14. Байгууллагын шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан нь тухайн байгууллага дараах гэх мэт тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн өөр сууриас шилжих үеийн санхүүгийн тайлан юм:
- (а) Өөрийн хамгийн сүүлийн, өмнөх тайлант үеийн санхүүгийн тайланг УСНББОУС, *Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурийн дагуух Санхүүгийн Тайлагнал*-ын дагуу бэлтгэсэн;
  - (б) Өөрийн хамгийн сүүлийн, өмнөх тайлант үеийн санхүүгийн тайланг доорх байдлаар толилуулсан:
    - (i) УСНББОУС-тай бүх талаараа үл нийцэх тогтоосон шаардлагуудын дагуу;
    - (ii) УСНББОУС-тай нийцсэн талаархи бүрэн тодорхой мэдэгдлийг уг санхүүгийн тайлан агуулаагүй байхаас бусад, бүх талаар УСНББОУС-тай нийцүүлэн;
    - (iii) Бүх биш боловч зарим УСНББОУС-тай нийцүүлсэн, үүн дотроо үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх энэ Стандартад заасан, чөлөөлөх нөхцлүүдийг (36-62-р параграфыг үзнэ үү) мөрдсөн талаархи тодорхой мэдэгдлийг агуулах;
    - (iv) Тогтоосон шаардлагууд байхгүй зүйлсийг тайлагнахын тулд бие даасан зарим УСНББОУС-ыг ашиглах ба УСНББОУС-тай үл нийцэх тийм тогтоосон шаардлагуудын дагуу; эсвэл
    - (v) УСНББОУС-ын дагуу тодорхойлсон дүнтэй зарим дүнг тохируулахын хамтаар тэдгээр тогтоосон шаардлагуудын дагуу;
  - (в) Гаднын хэрэглэгчдэд танилцуулахгүйгээр зөвхөн дотооддоо ашиглах зорилгоор санхүүгийн тайлангаа УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн;
  - (г) УСНББОУС 1-д тодорхойлсон иж бүрэн санхүүгийн тайланг бэлтгэхгүйгээр зөвхөн нэгтгэлийн зорилгоор тайлагналын багцыг УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн; эсвэл
  - (д) Өмнөх тайлант үеүдийн хувьд санхүүгийн тайланг толилуулаагүй.

## **Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт**

### **УСНББОУС-д нийцсэн эхлэлийн санхүүгийн байдлын тайлан**

15. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх эхлэлийн санхүүгийн байдлын тайланг бэлтгэж, толилуулна. Энэ нь түүний нягтлан бодох бүртгэлийг аккруэл суурьт УСНББОУС-тай нийцүүлэх эхлэлийн цэг болно.**

### **Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

16. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь энэ УСНББОУС-д шаардсан буюу өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд УСНББОУС-ын**

**шаардлагуудыг аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буцаах горимоор мөрдөнө.**

17. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь 36-134-р параграфт тусгайлан зааснаас бусад тохиолдолд эхлэлийн санхүүгийн байдлын тайланд болон толилуулсан бүх тайлант үеүдийн туршид нэг ижил нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг мөрдөнө. Тэдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь 36-134-р параграфт тусгайлан зааснаас бусад тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр хүчин төгөлдөр байгаа бүх УСНББОУС-тай нийцсэн байна.**
18. 36-134-р параграфт заасан чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг, анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох зүйлсийг хүлээн зөвшөөрсөн, хэмжсэн ба холбогдох мэдээллийг тухайн санхүүгийн тайланд зохих УСНББОУС-ын дагуу толилуулж, тодруулсны (аль түрүүнд болох өдрийн) дараа өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулах шаардлагатай болдог.
19. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр хүчин төгөлдөр байгаа аккруэл суурьт УСНББОУС-ын хувилбарыг мөрдөнө. Хэрэв тухайн УСНББОУС нь дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрдөг бол анх удаа мөрдөж буй байгууллага нь хараахан албан ёсоор хүчин төгөлдөр болоогүй байгаа уг шинэ УСНББОУС-ыг мөрдөж болох юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн шилжилтийн үеийн туршид хүчин төгөлдөр болсон аливаа шинэ УСНББОУС-ыг түүний хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдөнө.
20. 36-134-р параграфт зааснаас бусад тохиолдолд, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа:
  - (а) УСНББОУС-уудын дагуу хүлээн зөвшөөрөхийг шаарддаг бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө;
  - (б) Хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС-уудаар зөвшөөрдөггүй зүйлсийг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөхгүй;
  - (в) Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу нэг төрлийн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг байдлаар хүлээн зөвшөөрсөн зүйлс нь УСНББОУС-ын дагуу өөр төрлийн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг болохоор байвал тэдгээрийг дахин ангилна;
  - (г) Хүлээн зөвшөөрсөн бүх хөрөнгө, өр төлбөрийг хэмжихдээ УСНББОУС-ыг мөрдөнө.
21. Анх удаа мөрдөж буй байгууллагын санхүүгийн тайландаа ашигладаг нягтлан бодох бүртгэлийн бодлого нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу түүний зэрэгцүүлэгдэх тайлант үеийн эцэст мөрдөж байсан нягтлан бодох бүртгэлийн бодлогоос өөр байж болно. Үүний үр дүн болох залруулга нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнөх ажил гүйлгээ, бусад

үйл явдал буюу нөхцөл байдлаас үүсдэг. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн зүйлсийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн тайлант үеийн хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд (хэрэв тохиромжтой бол цэвэр хөрөнгө/өмчийн бусад ангилалд) тэдгээр залруулгыг хүлээн зөвшөөрнө. Анх удаа мөрдөж буй байгууллага нь толилуулсан хамгийн эхний тайлант үед тэдгээр залруулгыг хүлээн зөвшөөрнө.

22. Аккруэл суурьт УСНББОУС-ыг угаасаа мөрддөг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо оруулсан өөрчлөлтийн хувьд бусад УСНББОУС-уудын шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон заалтуудыг мөрдөнө. Анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр ба шилжилтийн үеийн туршид өөрийн жилийн санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулахдаа энэ Стандартын шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон заалтуудыг мөрдөнө.

### **УСНББОУС-ыг буцаах горимоор мөрдөлтийн гажих нөхцлүүд**

23. Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийж байсан тооцоолол нь УСНББОУС-ын шаардлагуудтай нийцэхгүй гэсэн бодит нотолгоо байхаас бусад тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллагын УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр УСНББОУС-д нийцүүлэн хийсэн тооцоолол нь тэрхүү өмнөх суурийн дагуу хийсэн (нягтлан бодох бүртгэлийн бодлогын аливаа зөрүүтэй байдлыг тусгах залруулгын дараах) тооцоололтой нийцсэн байна.
24. Энэхүү УСНББОУС нь аккруэл суурьт УСНББОУС-уудын зарим төлөв байдлыг буцаан мөрдөхийг хориглодог. Анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн тооцооллын талаархи мэдээллийг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойш хүлээн авч болох юм. 23-р параграфт заасанчлан, анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм мэдээлэл хүлээн авалтыг УСНББОУС 14, *Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал*-ын дагуу тайлант үеийн дараах үл тохируулагдах үйл явдалтай ижил арга замаар авч үзнэ.
25. Анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тухайн өдөр хийх шаардлагагүй байсан тооцооллыг уг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу шилжилтийн үед УСНББОУС-ын дагуу хийх шаардлагатай байж болох юм. УСНББОУС 14-тэй нийцүүлэхийн тулд УСНББОУС-уудын дагуу хийх ийм тооцоолол нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу шилжилтийн үеийн тэрхүү өдөр оршин байсан нөхцөл байдлыг тусгана. Ялангуяа, УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр буюу шилжилтийн үед зах зээлийн үнэ, хүүний түвшин, валютын ханшийн талаар хийсэн тооцоолол нь тухайн өдрөөрх зах зээлийн нөхцөл байдлыг тусгадаг. Үндсэн хөрөнгө гэх мэт санхүүгийн бус хөрөнгийн хувьд тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үлдэх өртөг болон төлөв байдлын талаархи тооцоолол нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу шилжилтийн үеийн тэрхүү өдрөөрх удирдлагын хүлээлт ба шүүн тунгаалтыг тусгасан байдаг.

26. Эхлэлийн санхүүгийн байдлын тайланд 23-25-р параграфыг мөрдөнө. Байгууллага нь 78-р параграфын дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн бол зэрэгцүүлэгдэх тайлант үеийн хувьд эдгээр параграфуудыг бас мөрдөнө. Энэ тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр гэсэн хэллэгийг тухайн зэрэгцүүлэгдэх тайлант үеийн эцэс гэсэн хэллэгээр орлуулна.

### **Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцэлт**

27. Анх удаа мөрдөж буй байгууллагын УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан нь тухайн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулна. Үнэн зөв толилуулга нь УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг шударга бодитой илэрхийлэхийг шаарддаг. Анх удаа мөрдөж буй байгууллага нь 36-62-р параграфт заасан, чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу холбогдох зүйлсийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл эдгээр чөлөөлөлт нь тухайн санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга, түүнчлэн аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх уг анх удаа мөрдөж буй байгууллагын чадвар боломжид нөлөө үзүүлнэ.
28. 11-р параграфт зааснаас бусад тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн өдрөөр хүчин төгөлдөр байгаа зохих УСНББОУС-уудын бүх шаардлагуудыг даган мөрдсөн зөвхөн тийм үед УСНББОУС-тай бүрэн нийцсэн гэж мэдэгдэнэ. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь 36-62-р параграфт заасан, нэг буюу хэд хэдэн чөлөөлөх нөхцлүүдийг мөрдсөн бол тухайн санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөө үзүүлнэ. Санхүүгийн тайлангаа УСНББОУС-тай нийцүүлсэн байгууллага нь ийм нийцлийн талаархи бүрэн тодорхой мэдэгдлийг тодруулгад тусган оруулах хэрэгтэй. Санхүүгийн тайлан нь УСНББОУС-ын бүх шаардлагуудтай нийцсэн байхаас бусад тохиолдолд түүнийг УСНББОУС-тай нийцсэн гэж илэрхийлж болохгүй бөгөөд аккруэл суурьт УСНББОУС-тай нийцээгүй санхүүгийн тайлан гэж тодорхойлно.
29. УСНББОУС 1-ийн 29-р параграфт заасанчлан, тохирох УСНББОУС-ыг даган мөрдсөнөөр бараг бүх нөхцөл байдалд үнэн зөв толилуулгад хүрдэг. Анх удаа мөрдөж буй байгууллага УСНББОУС-тай бүрэн нийцэлд хүрэхийн тулд 11-р параграфт дурдснаас бусад тохиолдолд чанарын шинжүүдийг хангах тийм арга маягаар тухайн мэдээллийг толилуулах үүднээс тохирох УСНББОУС-уудын бүх шаардлагуудыг даган мөрдөх шаардлагатай.
30. 36-62-р параграфт заасан чөлөөлөх нөхцлүүд нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр болон шилжилтийн үеийн туршид УСНББОУС-ын хүлээн зөвшөөрөлт,

хэмжилт, толилуулга, тодруулгын шаардлагуудаас чөлөөлдөг. Анх удаа мөрдөж буй байгууллага нь эдгээр чөлөөлөх нөхцлүүдийг ашиглах сонголт хийж болох боловч чөлөөлөх нөхцлүүдийг мөрдөх нь 27 ба 28-р параграфт заасанчлан, ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу холбогдох зүйлсийг хүлээн зөвшөөрөх, хэмжих буюу холбогдох мэдээллийг зохих УСНББОУС-ын дагуу толилуулах, тодруулах (аль түрүүнд болох өдөр) хүртэл тухайн санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн талаар мэдэгдэх уг байгууллагын чадвар боломжид нөлөөлөх эсэхийг харгалзан үзнэ. Ийм чөлөөлөх нөхцлүүдийг ашиглахын өмнө, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь холбогдох бүх баримт материал, нөхцөл байдал болон түүний санхүүгийн тайланд үзүүлэх боломжит үр нөлөөг харгалзан үзнэ.

31. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-д нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид уг мөрдсөн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд нөлөөлөх эсэхийг үнэлнэ.**
32. Жишээлбэл; анх удаа мөрдөж буй байгууллага нь гаргасан торгуулийн хуудасны үнийн дүн, хүчингүй болгосон торгуулийн дүн, зөрчил гаргагчтай хийсэн тохиролцоо зэргийн талаархи хангалттай мэдээлэл бэлэн байхгүйн улмаас замын хөдөлгөөний торгуулийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн хувьд чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацааг ашигладаг. Арилжааны бус орлогын аливаа бусад ангийн хувьд ийм чөлөөлөх хугацааг ашигладаггүй. Торгуулиас хүлээн авсан орлого нь бүхэлдээ тухайн санхүүгийн тайлангийн хувьд материаллаг бус байдаг. Шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон заалтуудыг ашиглах нь үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй гэж уг байгууллага дүгнэсэн. Иймээс уг анх удаа мөрдөж байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөх өдөр буюу шилжилтийн хугацааны туршид үнэн зөв толилуулгад хүрэх ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх боломжтой хэвээр байна.

### **Шилжилтийн үед үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх чөлөөлөх нөхцлүүд**

33. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь 36-62-р параграфт заасан, чөлөөлөх нөхцлүүдийг мөрдөж болох юм. Эдгээр чөлөөлөх нөхцлүүд нь 27, 28-р параграфт заасанчлан, тэдгээрийг мөрдөж байх шилжилтийн хугацаанд уг анх удаа мөрдөж буй байгууллагын санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлнө. Анх удаа мөрдөж буй байгууллага нь эдгээр чөлөөлөх нөхцлүүдийг бусад зүйлсэд адилтган мөрдөж болохгүй.**
34. **36-62-р параграфт заасан чөлөөлөх нөхцлүүдийг үл харгалзан, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь холбогдох УСНББОУС-ын бүх шаардлагуудыг боломжтой болсон тэр даруйд бүрэн даган мөрдөхийг дэмжинэ.**



35. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь 36-62-р параграфт заасан, чөлөөлөх нөхцлүүдийг мөрддөг тохиолдолд ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах эсвэл холбогдох зүйлсийг зохих УСНББОУС-ын дагуу санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл тэдгээр УСНББОУС-ын аливаа хамаарах толилуулгын болон тодруулгын шаардлагуудыг мөрдөх албагүй юм.**

**Хөрөнгө ба/буюу өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн хувьд чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацаа**

*Хөрөнгө ба/буюу өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт*

36. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөггүй тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үеүдийн хувьд дараах хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх буюу хэмжих шаардлагагүй юм:**
- (а) **Бараа материал (УСНББОУС 12, *Бараа материал*-ыг үзнэ үү);**
  - (б) **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-ийг үзнэ үү);**
  - (в) **Үндсэн хөрөнгө (УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийг үзнэ үү);**
  - (г) **Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр ба ажилтны урт хугацааны бусад тэтгэмж (УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг үзнэ үү);**
  - (д) **Биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй*-г үзнэ үү);**
  - (е) **Биет бус хөрөнгө (УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийг үзнэ үү);**
  - (ж) **Санхүүгийн өр төлбөрийн загвар эсвэл эзэмшигчид эрх олгох загварын дагуух үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр (УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ийг үзнэ үү);**
  - (и) **Санхүүгийн хэрэглүүр (УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийг үзнэ үү).**
37. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь 36(г) параграфт заасан чөлөөлөх нөхцлийг мөрддөг бол тухайн үүрэг болон хөтөлбөрийн аливаа холбогдох хөрөнгийг мөн тэр үеэс хүлээн зөвшөөрнө.**
38. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь 36-р параграфт дурдсан хөрөнгө, өр төлбөрийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрдөг тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант**

**үeдийн хувьд тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн хэмжилтийн талаархи нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчлөх шаардлагагүй юм.**

39. 36 ба 38-р параграфт зааснаас бусад тохиолдолд, анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үeдийн хувьд хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн талаархи өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх шаардлагагүй юм. 36 ба 38-р параграфт заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд нь тухайн шилжилтийн хугацааны туршид хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх болон хэмжих найдвартай<sup>1</sup> загварыг боловсруулах боломжийг уг анх удаа мөрдөж буй байгууллагад тэрхүү тайлант үед олгох санаа зорилготой байдаг. Анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд бусад УСНББОУС-ын заалтуудтай үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөж болох юм.
40. **36 ба 38-р параграфт зааснаас бусад тохиолдолд, анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо аккрузл суурьт УСНББОУС-тай илүү сайн нийцүүлэхийн тулд тухайн шилжилтийн хугацааны туршид зөвхөн өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх бөгөөд ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах эсвэл холбогдох зүйлсийг зохих УСНББОУС-ын дагуу санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл тэрхүү одоо байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэвээр мөрдөж болох юм. Анги буюу ангилал ашиглахыг зохих УСНББОУС-аар зөвшөөрсөн тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг анги бүрээр буюу ангилал бүрээр өөрчилж болно.**
41. Санхүүгийн хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг 36 ба 38-р параграфын чөлөөлөх нөхцлүүдийг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь мөрддөг тохиолдолд аливаа холбогдох орлогыг УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ын нөхцлүүдийн дагуу, эсвэл мөнгөн буюу бусад санхүүгийн хөрөнгөөр барагдуулах бусад авлагыг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ын нөхцлүүдийн дагуу хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжих шаардлагагүй юм.

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

*Арилжааны бус орлогын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

42. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үеүдийн хувьд арилжааны бус орлогын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн талаархи өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх шаардлагагүй юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээний орлогын хувьд өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг анги бүрээр өөрчилж болно.**
43. 42-р параграфт заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд нь тухайн шилжилтийн хугацааны туршид арилжааны бус ажил бус ажил гүйлгээнээс үүссэн орлогыг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ын дагуу хүлээн зөвшөөрөх болон хэмжих найдвартай загварыг боловсруулах боломжийг уг анх удаа мөрдөж буй байгууллагад тэрхүү тайлант үед олгох санаа зорилготой байдаг. Анх удаа мөрдөж буй байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд УСНББОУС 23-ын заалтуудтай үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөж болох юм. 42-р параграфт заасан, шилжилтийн нөхцөл нь арилжааны бус ажил гүйлгээний орлогын янз бүрийн ангиудын хувьд УСНББОУС 23-ыг дэс дараалан мөрдөх боломжийг уг анх удаа мөрдөж буй байгууллагад олгодог. Жишээлбэл; анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдөж эхэлсэн өдрөөс үл хөдлөх хөрөнгийн татвар болон бусад зарим төрлийн шилжүүлгийг УСНББОУС 23-ын дагуу хүлээн зөвшөөрөх ба хэмжих боломжтой байж болох боловч орлогын татварын орлогыг хүлээн зөвшөөрөх, хэмжих найдвартай загварыг бүрэн боловсруулахад гурван жил шаардагдаж болох юм.

*Бусад чөлөөлөх нөхцлүүд*

**УСНББОУС 5, Зээлийн Өртөг**

44. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг 36-р параграфын чөлөөлөх нөхцлийг мөрддөг бөгөөд зөвшөөрөгдсөн сонголтот аргын дагуу зээлийн өртгийг тайлагнах сонголт хийсэн тохиолдолд капиталжуулалтыг эхлэх өдөр нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнөх байх уг шалгуур хангах хөрөнгүүдийн хувьд аливаа зээлийн өртгийг ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дуусах эсвэл холбогдох хөрөнгүүдийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөх, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл капиталжуулах шаардлагагүй юм.**
45. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жил хүртэлх хугацаанд УСНББОУС 16, 17, 27, 31, 32-ын дагуу хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг 36-р параграфар зөвшөөрдөг. Уг анх удаа мөрдөж буй байгууллага нь зөвшөөрөгдсөн сонголтот аргыг ашиглан зээлийн өртгийг капиталжуулах

үедээ эдгээр УСНББОУС-уудын шаардлагуудыг мөн энэ хугацаанд харгалзан үзэх шаардлагатай байж болох юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 16, 17, 27, 31, 32-ын дагуу хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ уг шилжилтийн үеийн чөлөөлөх хугацааны давуу талыг ашигладаг тохиолдолд тэрхүү шилжилтийн үеэс өмнө буюу шилжилтийн хугацаанд тухайн шалгуур хангах хөрөнгийн хувьд гарсан зээлийн өртгийг капиталжуулах шаардлагагүй юм. Ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох хөрөнгүүдийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн (аль түрүүнд болох өдөр) зөвхөн тийм тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн шалгуур хангах хөрөнгийн хувьд гарсан зээлийн өртгийг уг зөвшөөрөгдсөн сонголтот аргын дагуу капиталжуулахыг зөвшөөрдөг.

### **УСНББОУС 13, Түрээс**

46. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй байхыг зөвшөөрдөг 36-р параграфын чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгүүдийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөх (аль түрүүнд болох өдөр) хүртэл санхүүгийн түрээстэй холбоотой шаардлагуудыг мөрдөх албагүй юм.**
47. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс эхлэн гурав хүртэлх жилийн хугацаанд хөрөнгийг УСНББОУС 16, 17, 27, 31, 32-ын дагуу хүлээн зөвшөөрөхгүй байхыг энэхүү УСНББОУС-аар зөвшөөрдөг. Уг анх удаа мөрдөж буй байгууллага нь энэхүү УСНББОУС-д заасан санхүүгийн түрээсийн хүлээн зөвшөөрөлтийг харгалзан үзэх үедээ эдгээр УСНББОУС-уудын шаардлагуудыг мөн энэ хугацаанд харгалзан үзэх шаардлагатай байж болох юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 16, 17, 27, 31, 32-ын дагуу уг чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг тохиолдолд ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгүүдийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөх (аль түрүүнд болох өдөр) хүртэл санхүүгийн түрээсийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй юм.

### **УСНББОУС 19, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө**

48. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь үндсэн хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг 36-р параграфын чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд УСНББОУС 17-гийн ийм чөлөөлөлтийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгийг УСНББОУС 17-гийн дагуу хүлээн зөвшөөрөх буюу хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл тухайн үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын анхны тооцоололтой холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх буюу хэмжих шаардлагагүй юм.**

49. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс эхлэн гурав хүртэлх жилийн хугацаанд үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг энэхүү УСНББОУС-аар зөвшөөрдөг. Байгууллага нь үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын анхны тооцооллыг тухайн үндсэн хөрөнгийн өртгийн нэг хэсэг байдлаар тусган оруулахыг УСНББОУС 17-гоор шаарддаг. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн шилжилтийн хугацаа олгодог чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигласан тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгийг УСНББОУС 17-гийн дагуу хүлээн зөвшөөрөх буюу хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл тухайн үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын анхны тооцооллолтой холбоотой шаардлагуудыг мөрдөх албагүй юм. Өр төлбөрийг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр хүлээн зөвшөөрнө, эсвэл уг анх удаа мөрдөж буй байгууллага нь үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн шилжилтийн хугацаа олгодог чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дуусах ба/буюу тухайн хөрөнгийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөх буюу хэмжих өдрөөр тэрхүү өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.
50. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь 48-р параграфт заасан, чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тухайн үүрэг болон холбогдох аливаа хөрөнгийг мөн тэр үед хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжинэ.**

#### **УСНББОУС 20, Холбоотой Талуудын Тодруулга**

51. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үеүдийн хувьд холбоотой талуудын харилцаа, холбоотой талуудын ажил гүйлгээ, эрх бүхий албан тушаалтны талаархи мэдээллийг тодруулах шаардлагагүй юм.
52. 51-р параграфт заасан шилжилтийн нөхцлийг үл харгалзан, анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр мэдэгдэж байгаа холбоотой талуудын харилцаа, холбоотой талуудын ажил гүйлгээ, эрх бүхий албан тушаалтны талаархи мэдээллийг тодруулахыг дэмжинэ.

#### **УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан, УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан, УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт**

53. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь

оролцоог нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрдөггүй байсан тохиолдолд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үеүдийн хувьд бусад байгууллагууд дахь өөрийн хувь оролцоог хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр байдлаар хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжих шаардлагагүй юм.

54. 53-р параграфт зааснаас бусад тохиолдолд, анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үеүдийн хувьд хяналтанд буй байгууллага, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь оролцооны хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн талаархи нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчлөх шаардлагагүй юм. 53-р параграфт заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд нь бусад байгууллагууд дахь өөрийн хувь оролцоогоо тухайн шилжилтийн хугацааны туршид хяналтанд буй байгууллага, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр гэж тодорхойлох ба зохих ёсоор ангилах боломжийг уг анх удаа мөрдөж буй байгууллагад олгох санаа зорилготой байдаг. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь оролцооны хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд бусад УСНББОУС-ын заалтуудтай үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөж болох юм.

#### **УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан**

55. **53-р параграфт зааснаас бусад тохиолдолд, анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараа, нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулна. Гэвч нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулж байгаа уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үеүдийн хувьд тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох бүх үлдэгдлүүд, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэх шаардлагагүй юм.**
56. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хяналтанд буй байгууллагуудын хоорондох маш олон тооны ажил гүйлгээ бүхий хяналтанд буй байгууллагуудтай байж болох юм. Үүний улмаас тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх зорилгын хувьд устгах шаардлагатай зарим ажил гүйлгээ болон үлдэгдлүүдийг тодорхойлоход төвөгтэй байж болно. Энэ шалтгааны улмаас эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох үлдэгдлүүд, ажил гүйлгээ, орлого, зардлыг бүрэн устгаж цэвэрлэхэд гурван жил хүртэлх хугацааны чөлөөлөлтийг 55-р параграфтаар олгодог.
57. **55-р параграфт заасан шилжилтийн чөлөөлөх нөхцлийг үл харгалзан, анх удаа мөрдөж буй байгууллага нь аль болох боломжит хэмжээгээр**

**УСНББОУС 35-ын нөхцлүүдийг бүрэн даган мөрдөхийн тулд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр мэдэгдэж байгаа тэдгээр үлдэгдлүүд, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэхийг дэмжинэ.**

58. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь 53 ба/буюу 55-р параграфт заасан, шилжилтийн чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг тохиолдолд дараах нөхцөл (аль нэг нь түрүүлж) биелэгдэх хүртэл нэгтгэсэн санхүүгийн тайлан байдлаар өөрийн санхүүгийн тайлангаа толилуулахгүй:**
- (а) **Чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах;**
  - (б) **Бусад байгууллагууд дахь өөрийн хувь оролцоог хяналтанд буй байгууллага, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр байдлаар зохих ёсоор хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжих; эсвэл**
  - (в) **Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох үлдэгдлүүд, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэх.**

**УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт**

59. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 36-г мөрдөхдөө өмчийн аргыг ашигладаг тохиолдолд тухайн хөрөнгө оруулагч болон түүний хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн хоорондох “дээш чиглэсэн” ба “доош чиглэсэн” ажил гүйлгээний үр дүнд ашиг, алдагдал дахь өөрийн хувь оролцоог тэрхүү хөрөнгө оруулагч нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үеүдийн хувьд устгаж цэвэрлэх шаардлагагүй юм.**
60. **УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө оруулагч ба санхүүжигчийн хоорондох “дээш чиглэсэн” ба “доош чиглэсэн” маш олон тооны ажил гүйлгээ бүхий нэг буюу хэд хэдэн хараат байгууллага болон хамтарсан үйлдвэрийн хувьд хөрөнгө оруулагч байж болох юм. Үүний улмаас өмчийн аргыг хэрэглэх үедээ, уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн ашиг, алдагдал дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог устгах шаардлагатай “дээш чиглэсэн” ба “доош чиглэсэн” зарим ажил гүйлгээг тодорхойлоход төвөгтэй байж болно. Энэ шалтгааны улмаас тэдгээр “дээш чиглэсэн” ба “доош чиглэсэн” ажил гүйлгээний үр дүн болох уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн ашиг, алдагдал дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог бүрэн устгаж цэвэрлэхэд гурван жил хүртэлх хугацааны чөлөөлөлтийг 59-р параграфтаар хөрөнгө оруулагчид олгосон байдаг.**
61. **59-р параграфт заасан шилжилтийн чөлөөлөх нөхцлийг үл харгалзан, анх удаа мөрдөж буй байгууллага нь аль болох боломжит хэмжээгээр УСНББОУС 36-гийн нөхцлүүдийг бүрэн даган мөрдөхийн тулд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр мэдэгдэж байгаа “дээш чиглэсэн” ба**

“доош чиглэсэн” ажил гүйлгээний үр дүн болох уг хараат байгууллага болон хамтарсан үйлдвэрийн ашиг, алдагдал дахь өөрийн хувь оролцоог устгаж цэвэрлэхийг дэмжинэ.

62. Анх удаа мөрдөж буй байгууллага нь 53 ба/буюу 55-р параграфт заасан, шилжилтийн чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг тохиолдолд хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг өмчийн арга ашиглан тайлагнаж, тусгасан санхүүгийн тайлангаа дараах нөхцөл (аль нэг нь түрүүлж) биелэгдэх хүртэл толилуулахгүй:
- (a) Чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах;
  - (б) Бусад байгууллагууд дахь өөрийн хувь оролцоог хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр байдлаар зохих ёсоор хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжих; эсвэл
  - (в) Хөрөнгө оруулагч ба санхүүжигчийн хоорондох “дээш чиглэсэн” болон “доош чиглэсэн” ажил гүйлгээний үр дүн болох уг хараат байгууллагын ашиг, алдагдал дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог устгаж цэвэрлэх.

#### УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл

- 62А. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө, өр төлбөрийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг 36-р параграфын чөлөөлөх нөхцлийг мөрддөг тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацааны туршид улсын секторын нэгдлийн оролцогч тал байж болох юм. Ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгө, өр төлбөрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл уг анх удаа мөрдөж буй байгууллага нь нь тэрхүү улсын секторын нэгдэлтэй холбоотой хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжих шаардлагагүй юм.
- 62Б. Анх удаа мөрдөж буй байгууллага нь дээрх 62А параграфт дурдсан, чөлөөлөх нөхцлийг мөрддөг тохиолдолд улсын секторын нэгдэлтэй холбоотойгоор гүүдвилийг хүлээн зөвшөөрөхгүй. Анх удаа мөрдөж буй байгууллага нь доорх (а) ба (б) заалтад дурдсан дүнгүүдийн хоорондох зөрүүг цэвэр хөрөнгө/ өмчид хүлээн зөвшөөрнө:
- (a) Дараах дүнгүүдийн нийлбэр:
    - (i) Шилжүүлсэн аливаа төлбөр;
    - (ii) Худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоо;
    - (iii) Худалдан авсан үйл ажиллагааны хувьд өмнө нь эзэмшиж байсан аливаа өмчийн хувь оролцоо.



- (б) **Олж эзэмшсэн аливаа тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн цэвэр дүн.**

62В. УСНББОУС 40-ийг гүйцээх горимоор мөрдөнө. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 40-ийг мөрдөхөөс өмнө хийгдсэн улсын секторын нэгдлийн үр дүнд хүлээн зөвшөөрсөн гүүдвилийн аливаа дүнг залруулахгүй.

### **Мөрдөх хугацаанд үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй чөлөөлөх нөхцлүүд**

63. Анх удаа мөрдөж буй байгууллага нь 64-134-р параграфт заасан, чөлөөлөх нөхцлүүдийг мөрдөх шаардлагатай буюу ингэж мөрдөх сонголт хийж болох юм. Эдгээр чөлөөлөх нөхцлүүд нь 27, 28-р параграфт заасанчлан, тэдгээрийг мөрдөж байх шилжилтийн хугацаанд уг анх удаа мөрдөж буй байгууллагын санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөхгүй. Анх удаа мөрдөж буй байгууллага нь эдгээр чөлөөлөх нөхцлүүдийг бусад зүйлсэд адилтган мөрдөж болохгүй.

### **Хөрөнгө ба/буюу өр төлбөрийг хэмжихэд төсөөлөн тооцсон өртөг ашиглах**

64. Хөрөнгө, өр төлбөрийн талаархи өртгийн найдвартай мэдээлэл байхгүй тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь дараах хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмжих ба тэрхүү бодит үнэ цэнийг эдгээр хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртөг болгон ашиглах сонголт хийж болох юм:

- (а) Бараа материал (УСНББОУС 12-ыг үзнэ үү);
- (б) Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 16-д заасан өртгийн загварыг ашиглах сонголт хийсэн бол Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө;
- (в) Үндсэн хөрөнгө (УСНББОУС 17-г үзнэ үү);
- (г) Дараах шалгуурыг хангасан бөгөөд дотооддоо бий болгосноос бусад биет бус хөрөнгө (УСНББОУС 31-ийг үзнэ үү):
  - (i) УСНББОУС 31-д заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуур (найдвартай хэмжилтийн шалгуур хамаарахгүй); ба
  - (ii) УСНББОУС 31-д заасан дахин үнэлгээний шалгуур (үүн дотроо, идэвхитэй зах зээлийн оршин байдал хамаарна);
- (д) Санхүүгийн хэрэглүүр (УСНББОУС 29-ийг үзнэ үү);
- (е) Үйлчилгээний концессын хөрөнгө (УСНББОУС 32-ыг үзнэ үү).

65. Хөрөнгө ба/буюу өр төлбөрийн олж эзэмшилтийн өртөг нь бэлэн боломжтой байхгүй зөвхөн тийм тохиолдолд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлж болно. Төсөөлөн тооцсон өртөг нь тухайн тодорхой өдөр

хөрөнгө, өр төлбөрийг уг байгууллага анх хүлээн зөвшөөрөх байсан дүнг гэж үздэг. Олж эзэмших өртөг нь тухайн төсөөлөн тооцсон өртөгтэй тэнцүү байна гэсэн урьдчилсан нөхцөлд үндэслэн дараагийн тайлант үеийн элэгдэл буюу хорогдуулгыг уг төсөөлөн тооцсон өртгөөс тооцоолдог. Жишээлбэл; үндсэн хөрөнгийн зүйлийн талаархи өртгийн мэдээлэл нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр бэлэн боломжтой байхгүйн байсны улмаас анх удаа мөрдөж буй байгууллага нь үндсэн хөрөнгийг уг өдөр түүний төсөөлөн тооцсон өртгөөр хэмжих ба бодит үнэ цэнийг тэрхүү өдрөөрх төсөөлөн тооцсон өртөг болгон ашиглах сонголт хийж болох юм. Аливаа дараагийн тайлант үеийн элэгдэл нь уг өдрөөр тодорхойлсон бодит үнэ цэнэд үндэслэх бөгөөд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлсон өдрөөс эхлэн элэгдлийг тооцоолно.

66. Төсөөлөн тооцсон өртөг ашиглахыг дахин үнэлгээ эсвэл бусад УСНББОУС-д заасан, дараагийн тайлант үеийн хэмжилтэнд бодит үнэ цэнийн загвар ашиглалт гэж үзэхгүй.
67. **Хэрэв нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний дүн нь тэрхүү үнэлгээний өдрөөр дараах зүйлстэй ерөнхийдөө зэрэгцүүлэгдэх боломжтой байвал анх удаа мөрдөж буй байгууллага нь түүнийг төсөөлөн тооцсон өртөг болгон ашиглах сонголт хийж болно:**
- (a) **Бодит үнэ цэнэ; эсвэл**
  - (b) **УСНББОУС-д нийцсэн, тухайлбал үнийн ерөнхий буюу тусгай индексийн өөрчлөлтийг тусгахын тулд тохируулга хийсэн өртөг эсвэл элэгдэл тооцсон өртгийн аль тохиромжтой дүн.**
68. Анх удаа мөрдөж буй байгууллага нь тодорхой үйл явдлын улмаас үндсэн хөрөнгийг тухайн нэг өдөр бодит үнэ цэнээр хэмжсэнээр түүний төсөөлөн тооцсон өртгийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тодорхойлж болно:
- (a) Хэрэв хэмжилтийн өдөр нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр эсвэл түүнээс өмнө байвал анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм үйл явдлаас хамаарах бодит үнэ цэнийн хэмжилтийг тэрхүү хэмжилтийн өдөр УСНББОУС-ын зорилгын хувьд төсөөлөн тооцсон өртөг байдлаар ашиглаж болно.
  - (b) Хэрэв хэмжилтийн өдөр нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойш боловч анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тэрхүү шилжилтийн хугацааны дотор байвал уг үйл явдал гарч тохиолдсон үед үйл явдлаас хамаарах бодит үнэ цэнийн хэмжилтийг төсөөлөн тооцсон өртөг байдлаар ашиглаж болно. Анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн үед тэрхүү үр дүн болох тохируулгыг хуримтлагдсан ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрнө.

69. 67-р параграфын дагуу бодит үнэ цэнийг тодорхойлохдоо, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь бодит үнэ цэнийн тодорхойлолт, түүнчлэн тухайн авч үзэж буй хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлох талаар бусад холбогдох УСНББОУС-д заасан, заавар удирдамжийг мөрдөнө. Бодит үнэ цэнэ нь түүнийг тодорхойлох өдрөөр оршин байсан нөхцөл байдлыг тусгана.
70. Бараа материал буюу тусгай шинж чанартай хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд бодит үнэ цэнийн талаархи зах зээлд суурилсан найдвартай нотолгоо бэлэн боломжтой байхгүй бол уг анх удаа мөрдөж буй байгууллага нь төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлохдоо, хэмжилтийн дараах хувилбаруудыг харгалзан үзэж болно:
- (а) Бараа материалын хувьд, одоогийн орлуулалтын өртөг; ба
  - (б) Тусгай шинж чанартай хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд, элэгдэл тооцсон орлуулалтын өртөг.

**Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг хэмжихэд төсөөлөн тооцсон өртөг ашиглах**

71. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийн талаархи өртгийн найдвартай мэдээлэл байхгүй тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр хэмжих ба бодит үнэ цэнийг уг хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртөг болгон ашиглах сонголт хийж болно.

**Хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах (УСНББОУС 34)**

72. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа өртгөөр хэмждэг бол УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг байгууллага нь тэрхүү хөрөнгө оруулалтыг дараах дүнгүүдийн аль нэгээр өөрийн эхлэлийн, тусдаа санхүүгийн байдлын тайландаа хэмжих сонголт хийж болно:
- (а) Өртөг; эсвэл
  - (б) Төсөөлөн тооцсон өртөг. Ийм хөрөнгө оруулалтын төсөөлөн тооцсон өртөг нь уг анх удаа мөрдөж буй байгууллага өөрийн тусдаа санхүүгийн тайландаа УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх түүний бодит үнэ цэнэ (УСНББОУС 29-ийн дагуу тодорхойлсон) байна.
73. Анх удаа мөрдөж буй байгууллага нь тодорхой үйл явдлын улмаас хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг тухайн нэг өдөр бодит үнэ цэнээр хэмжсэнээр түүний төсөөлөн тооцсон өртгийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх

суурийн дагуу тодорхойлж болно. Энэ тохиолдолд, анх удаа мөрдөж буй байгууллага нь 72(а) ба (б) параграфыг мөрдөнө.

### **Төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлж болох өдөр**

74. **Зарим хөрөнгө ба/буюу өр төлбөрийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь ашигладаг эсэхээс хамааран тэрхүү төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлох өдөр нь өөр өөр байж болно. Анх удаа мөрдөж буй байгууллага нь чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол төсөөлөн тооцсон өртгийг энэхүү тайлант үеийн турш дахь дурын өдрөөр эсвэл чөлөөлтийн хугацаа дууссан өдрөөр (аль түрүүнд болох өдрөөр) тодорхойлох бөгөөд түүнийг 76-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө. Харин чөлөөлөлтийн нөхцлийг ашигладаггүй бол уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлангаа толилуулсан хамгийн эхний тайлант үеийн эхэнд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлно.**
75. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгө, өр төлбөрийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү гурван жилийн шилжилтийн хугацааны доторх тодорхой нэг агшны байдлаар тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлж болно.
76. **Хөрөнгө, өр төлбөрийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тэрхүү тайлант үед төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлсон бол анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн хөрөнгө, өр төлбөрийн төсөөлөн тооцсон өртгийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн тайлант жилийн хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд уг залруулгыг хүлээн зөвшөөрнө.**

### **УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Толилуулга**

#### *Зэрэгцүүлэгдэх мэдээлэл*

77. Анх удаа мөрдөж буй байгууллага нь энэхүү УСНББОУС-ын дагуу толилуулсан өөрийн шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайландаа зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулахыг түүнээс шаарддаггүй боловч ингэж толилуулахыг дэмжинэ. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулдаг тохиолдолд түүнийг УСНББОУС 1-ийн шаардлагуудын дагуу толилуулна.
78. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн тохиолдолд шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан эсвэл энэхүү УСНББОУС-ын

**дагуу толилуулсан УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан нь дараах зүйлсийг агуулсан байна:**

- (а) Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл бүхий нэг санхүүгийн байдлын тайлан ба аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн өмнөх тайлант үеийн эхэн дэх эхлэлийн санхүүгийн байдлын тайлан;
- (б) Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл бүхий нэг санхүүгийн үр дүнгийн тайлан;
- (в) Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл бүхий нэг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан;
- (г) Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл бүхий нэг мөнгөн гүйлгээний тайлан;
- (д) Анх мөрдөж буй байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулдаг тохиолдолд тусдаа нэмэлт санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан дахь төсвийн багана байдлаар харуулсан, тухайн тайлант жилийн төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлт;
- (е) Холбогдох тодруулга, үүн дотроо 142-р параграфтаар шаардсанчлан зэрэгцүүлэгдэх мэдээлэл ба материаллаг тохируулгын талаархи хүүрнэсэн мэдээллийн тодруулга.

79. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулахгүй байх сонголт хийсэн тохиолдолд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараах түүний шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан эсвэл энэхүү УСНББОУС-ын дагуу толилуулсан УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан нь дараах зүйлсийг агуулсан байна:**

- (а) Нэг санхүүгийн байдлын тайлан ба аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх эхлэлийн санхүүгийн байдлын тайлан;
- (б) Нэг санхүүгийн үр дүнгийн тайлан;
- (в) Нэг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан;
- (г) Нэг мөнгөн гүйлгээний тайлан;
- (д) Анх мөрдөж буй байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулдаг бол тусдаа нэмэлт санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан дахь төсвийн багана байдлаар харуулсан, тухайн тайлант жилийн төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлт;
- (е) Холбогдох тодруулга ба 142-р параграфтаар шаардсанчлан материаллаг тохируулгын талаархи хүүрнэсэн мэдээллийн тодруулга.

80. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн зүйлийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй**

**байхыг зөвшөөрдөг 36-62-р параграфт заасан, чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол уг чөлөөлөлтийн хугацааны туршид түүнийг хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжсэний дараа тэрхүү зүйлийн талаархи мэдээлэл нь бэлэн олдоцтой болсон зөвхөн тийм үед УСНББОУС-ыг мөрдсөний дараагийн жилийн хувьд зэрэгцүүлэгдэх мэдээллийг тохируулна.**

81. УСНББОУС 1 нь санхүүгийн тайланд тайлагнасан бүх дүнгийн хувьд өмнөх тайлант үед хамаарах зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулахыг байгууллагаас шаарддаг. Анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн зүйлийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол зэрэгцүүлэгдэх тайлант үеийн хувьд уг зүйлийн талаархи мэдээлэл нь бэлэн олдоцтой болсон зөвхөн тийм үед тус байгууллага нь тэрхүү тайлант үед хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн зүйлийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг тухайн шилжилтийн хугацаанд толилуулна. Анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд тохируулга хийсний дараа УСНББОУС 1-д заасан, шаардлагуудыг даган мөрдөнө.

*УСНББОУС-д нийцээгүй, зэрэгцүүлэгдэх мэдээлэл*

82. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу толилуулж болно. Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу бэлтгэсэн зэрэгцүүлэгдэх мэдээлэл бүхий аливаа санхүүгийн тайланд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн мэдээллийг УСНББОУС-ын дагуу бэлтгээгүй, харин нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийг ашиглан бэлтгэсэн гэдгийг тэмдэглэх бөгөөд УСНББОУС-тай нийцүүлэхийн тулд шаардагдах байсан гол тохируулгын шинж төрлийг тодруулна.
83. Анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараах өөрийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан эсвэл шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайландаа УСНББОУС-д нийцээгүй, зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулсан бол УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан эсвэл шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд толилуулсан УСНББОУС-д нийцээгүй, зэрэгцүүлэгдэх мэдээллийн хувьд энэ Стандатад заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл, заалтыг мөрдөхгүй.

*УСНББОУС-д нийцээгүй, түүхэн тойм мэдээ*

84. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ын дагуу санхүүгийн тайлангаа толилуулсан хамгийн эхний тайлант үеэс өмнөх тайлант үеүдийн хувьд сонгосон түүхэн тойм мэдээг толилуулах сонголт хийж болно. Ийм тойм мэдээ нь УСНББОУС-ын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн шаардлагуудтай нийцсэн байхыг энэхүү УСНББОУС шаарддаггүй. Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу бэлтгэсэн

түүхэн тойм мэдээ бүхий аливаа санхүүгийн тайланд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн мэдээг УСНББОУС-ын дагуу бэлтгээгүй, харин нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийг ашиглан бэлтгэсэн гэдгийг илт тодорхой тэмдэглэх бөгөөд УСНББОУС-тай нийцүүлэхийн тулд шаардагдах байсан гол тохируулгын шинж төрлийг тодруулна. Анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм тохируулгыг үнийн дүнгээр илэрхийлэх шаардлагагүй юм.

#### **УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө**

85. **УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү өдрөөр оршин байсан, хуримтлагдсан ханшийн зөрүүгийн хувьд УСНББОУС-ын шаардлагуудыг даган мөрдөх албагүй юм. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь энэхүү чөлөөлөх нөхцлийг ашигладаг бол:**
- (a) Бүх гадаад үйл ажиллагааны хувьд хуримтлагдсан ханшийн зөрүүг УСНББОУС-д шилжсэн өдөр тэг гэж төсөөлнө; ба
  - (б) Аливаа гадаад үйл ажиллагааны дараагийн тайлант үеийн данснаас хасалтын олз гарзад тэрхүү УСНББОУС-д шилжсэн өдрөөс өмнө үүссэн ханшийн зөрүүг оруулахгүй, харин үүнээс хойшхи ханшийн зөрүүг оруулан тусгана.
86. **Гадаад үйл ажиллагааг худалдан авснаас үүссэн аливаа гүүдвил болон тухайн гадаад үйл ажиллагааны худалдан авалтаар үүссэн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд хийгдэх аливаа бодит үнэ цэнийн тохируулгыг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү гадаад үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөртэй адилаар УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс эхлэн гүйцээх горимоор тайлагнах шаардлагыг даган мөрдөнө (УСНББОУС 40-ийг үзнэ үү).**
87. 85-р параграфт заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийг мөрдөхдөө, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө худалдан авсан гадаад үйл ажиллагааны хувьд өмнөх жилүүдийн тайланг дахин илэрхийлэхгүй ба ингэснээр тэрхүү худалдан авалтаас үүссэн гүүдвил болон бодит үнэ цэнийн тохируулгыг хэрэв тохиромжтой бол гадаад үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөр гэж биш, харин тухайн байгууллагын хөрөнгө, өр төлбөр байдлаар тайлагнана. Иймээс тэдгээр гүүдвил болон бодит үнэ цэнийн тохируулгыг тухайн байгууллагын бүртгэлийн валютаар аль хэдийн илэрхийлсэн эсвэл уг олж эзэмшсэн өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлэн тайлагнасан байна.

#### **УСНББОУС 5, Зээлийн Өртөг**

88. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь бенчмарк хандлагыг мөрддөг эсвэл өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг бенчмарк хандлага болгон өөрчилсөн тохиолдолд УСНББОУС 5-ын шаардлагуудыг буцаах горимоор мөрдөхийг дэмжих боловч түүнээс заавал шаардахгүй.**

89. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь бенчмарк хандлагыг мөрддөг эсвэл өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг бенчмарк хандлага болгон өөрчилсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнөх дурын нэг өдрийг сонгох ба тэрхүү сонгосон өдрөөс буюу түүнээс хойш УСНББОУС 5-ыг гүйцээх горимоор мөрдөнө.**
90. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг зөвшөөрөгдсөн сонголтот арга болгон өөрчилсөн тохиолдолд капиталжуулалтыг эхлэх өдөр нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнөх байх уг шалгуур хангах хөрөнгүүдийн хувьд УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн өмнө ба дараа гарсан аливаа зээлийн өртгийг тэрхүү зөвшөөрөгдсөн сонголтот аргын дагуу буцаах горимоор хүлээн зөвшөөрнө.**

### **УСНББОУС 10, Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал**

#### *Ноцтой хэт инфляци*

91. **Анх удаа мөрдөж буй байгууллагын бүртгэлийн валют нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валют бол эсвэл тийм валют байсан бол тус байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө, уг валют ноцтой хэт инфляцид өртөж байсан эсэхийг тодорхойлно.**
92. Хэт инфляцитай эдийн засаг бүхий улс орны валют нь дараах хоёр шинж чанарын аль алиныг агуулсан бол ноцтой хэт инфляцид өртсөн байдаг:
- (а) Тухайн валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл бүхий бүх байгууллагын хувьд найдвартай үнийн ерөнхий индекс байхгүй.
  - (б) Тухайн валют ба харьцангуй тогтвортой гадаад валют хоёрын хооронд арилжаа хийх боломжгүй.
93. Анх удаа мөрдөж буй байгууллагын бүртгэлийн валют нь тухайн бүртгэлийн валютыг тогтворжуулсан өдрөөр хэт инфляцид өртөхөө больдог. Энэ нь тухайн бүртгэлийн валют 92-р параграфт заасан аль нэг шинжийг буюу хоёр шинжийн аль алиныг цаашид агуулахаа больсон өдөр эсвэл уг анх удаа мөрдөж буй байгууллага өөрийн бүртгэлийн валютаа хэт инфляцид өртөөгүй өөр валют болгон өөрчилсөн өдөр юм.
94. **Анх удаа мөрдөж буй байгууллагын УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь түүний бүртгэлийн валютыг тогтворжуулах өдөр буюу түүнээс хойш байх тохиолдолд тус анх удаа мөрдөж буй байгууллага нь уг бүртгэлийн валютын тогтворжуулах өдрөөс өмнө эзэмшиж байсан бүх хөрөнгө, өр төлбөрөө УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийж болно. Анх удаа мөрдөж буй байгууллага нь эхлэлийн санхүүгийн байдлын тайлан дахь тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн төсөөлөн тооцсон өртөг болгон уг бодит үнэ цэнийг ашиглаж болох юм.**



**УСНББОУС 13, Түрээс**

95. Түрээс үүсэх үед оршин байсан нөхцөл байдлууд нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хэрэв мэдэгдэж байвал анх удаа мөрдөж буй байгууллага нь одоо байгаа бүх түрээсийг тэдгээр нөхцөл байдлуудад үндэслэн үйл ажиллагааны эсвэл санхүүгийн түрээс гэж уг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр ангилна.
96. Харин түрээслэгч ба түрээслүүлэгч нь түрээс үүссэн өдөр болон аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн хоорондох хугацаанд түрээсийн гэрээний нөхцлийг өөрчлөхөөр тохиролцсон бөгөөд ингэснээр УСНББОУС-ыг мөрдсөн өдөр тухайн түрээсийн ангилал өөрчлөгдөхөөр болсон бол тэрхүү өөрчлөн засварласан гэрээг түрээсийн шинэ гэрээтэй адилаар авч үзнэ. Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр түрээсийг үйл ажиллагааны эсвэл санхүүгийн түрээс гэж ангилахдаа уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү шинэ түрээсийн гэрээний нөхцлийг харгалзан үзнэ.

**УСНББОУС 18, Сегментийн Тайлагнал**

97. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн доторх тодорхой нэг өдрөөс эхлэх тайлант үеүдийн хувьд сегментийн мэдээллийг толилуулах шаардлагагүй юм.

**УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт**

98. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг 36-р параграфын чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг тийм хөрөнгүүдтэй холбоотой байхаас бусад тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 21-ийн шаардлагуудыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс эхлэн гүйцээх горимоор мөрдөнө. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 16, 17, 27, 31, 32-т заасан, гурван жилийн шилжилтийн хугацаа олгох уг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тус байгууллага нь ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан ба/буюу холбогдох хөрөнгүүдийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн (аль түрүүнд болох өдөр) үед УСНББОУС 21-ийг мөрдөнө.
99. Ийм чөлөөлөлт олгосон шилжилтийн үеийн нөхцлүүдийн хугацаа дууссан эсвэл холбогдох хөрөнгүүдийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн, мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийн үнэ цэнэ буурсан гэсэн ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлнэ. Аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд эсвэл тухайн шилжилтийн үеийн

**чөлөөлөх нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох хөрөнгүүдийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн (аль түрүүнд болох өдөр) тайлант үед хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.**

100. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 21-ийн шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөнө. Энэ нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгүүдийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилттэй холбоотой шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийг мөрддөг бол тэрхүү гурван жилийн чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу анх мөрдөж буй байгууллага нь эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа тусгасан аливаа мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэсэн шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай бол холбогдох хөрөнгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, хэмжсэн зөвхөн тэр үе (аль түрүүнд болох өдөр) гэсэн үг юм.

### **УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж**

101. **36-р параграфт заасан чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр ба ажилтны урт хугацааны бусад тэтгэмжээс бусад, ажилтны бүх тэтгэмжийг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хүлээн зөвшөөрч, хэмжинэ.**

*Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр ба Ажилтны урт хугацааны бусад тэтгэмж*

102. **УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр ба ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хувьд өөрийн анхны өр төлбөрийг тухайн өдөр дараах байдлаар тодорхойлно:**
- (a) **УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) Төсөвлөсөн нэгжийн кредит аргыг ашиглан тооцсон тухайн үүргийн өнөөгийн үнэ цэнэ;**
  - (б) **УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) тухайн үүргийг шууд барагдуулахад ашиглах уг хөтөлбөрийн хөрөнгийн (хэрэв байгаа бол) бодит үнэ цэнийг хассан дүн;**

(в) [Хассан]

103. **102-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн, анхны өр төлбөр нь анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тухайн зэрэгцүүлэгдэх тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн өр төлбөрөөс их эсвэл бага байвал уг анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм нэмэгдэлт/бууралтыг тэрхүү зүйлийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн тайлант үед хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.**
104. Нягтлан бодох бүртгэлийн бодлогоо УСНББОУС 39-д нийцүүлэн өөрчилсөний үр нөлөө нь хэрэв байгаа бол өмнөх тайлант үеүүдэд хийгдсэн аливаа дахин хэмжилтийг агуулсан байна. Анх мөрдөж буй байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу ямар нэг өр төлбөрийг хүлээн зөвшөөрөөгүй ба/буюу хэмжээгүй байж болох бөгөөд энэ тохиолдолд өр төлбөрийн нэмэгдэлт нь тухайн өр төлбөрийн нийт дүнгээс 102(б) параграфт заасанчлан, УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөрх (аль түрүүнд болох өдрөөрх) уг хөтөлбөрийн аливаа хөрөнгийн бодит үнэ цэнийг хассан дүнг илэрхийлнэ.
105. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь хуримтлагдсан бүх дахин хэмжилтийг тухайн зүйлийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн тайлант үед хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.**
106. [Хассан]
107. [Хассан]

#### **УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт**

108. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг 36-р параграфын чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг тийм хөрөнгүүдтэй холбоотой байхаас бусад тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 26-гийн шаардлагуудыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс эхлэн гүйцээх горимоор мөрдөнө. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 16, 17, 27, 31, 32-т заасан, гурван жилийн шилжилтийн хугацаа олгох уг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тус байгууллага нь ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан ба/буюу холбогдох хөрөнгүүдийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн (аль түрүүнд болох өдөр) үед УСНББОУС 26-г мөрдөнө.**
109. **Ийм чөлөөлөлт олгосон шилжилтийн үеийн нөхцлүүдийн хугацаа дууссан эсвэл холбогдох хөрөнгүүдийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) уг анх**

удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн, мөнгө бий болгогч хөрөнгүүдийн үнэ цэнэ буурсан гэсэн ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлнэ. Аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд эсвэл тухайн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох хөрөнгүүдийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн (аль түрүүнд болох өдөр) тайлант үед хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.

110. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 26-гийн шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөнө. Энэ нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгүүдийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилттэй холбоотой шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийг мөрддөг бол тэрхүү гурван жилийн чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу анх мөрдөж буй байгууллага нь эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа тусгасан аливаа мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэсэн шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай бол холбогдох хөрөнгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, хэмжсэн зөвхөн тэр үе (аль түрүүнд болох өдөр) гэсэн үг юм.

#### **УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга**

111. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүр өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг ба цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийн аль алиныг агуулж буй эсэхийг тодорхойлохын тулд түүний нөхцлүүдийг үнэлж үзнэ. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг нь цаашид оршин байхааргүй бол уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг ба цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэгт салган зааглах шаардлагагүй юм.
112. Нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг анх үүссэн үед байгууллага нь түүнийг өр төлбөрийн болон цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсгүүдэд салган зааглахыг УСНББОУС 28-аар шаардсан байдаг. Өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг цаашид оршин байхгүй бол УСНББОУС 28-ыг буцаах горимоор мөрдөлт нь цэвэр хөрөнгө/өмчийн хоёр хэсгийг салган зааглахтай холбоотой байдаг. Эхний хэсэг нь хуримтлагдсан ашиг, алдагдалд тусгагдах бөгөөд уг өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт хамаарах хуримтлагдсан хүүг илэрхийлдэг. Нөгөө хэсэг нь анхны цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийг илэрхийлдэг. Гэвч УСНББОУС-ыг мөрдсөн өдөр өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг цаашид оршин байхгүй бол анх удаа мөрдөж буй байгууллага нь эдгээр хоёр хэсгийг салган зааглахгүй байхыг энэ УСНББОУС-аар зөвшөөрсөн байдаг.

**УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт**

*УСНББОУС-ыг мөрдсөн өдөр эсвэл шилжилтийн хугацаанд санхүүгийн хэрэглүүрийг ангилах*

113. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 29-д заасан, ангиллын шалгуурыг хангадаг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг 114-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр гэж ангилж болно. Анх удаа мөрдөж буй байгууллага нь ингэж ангилсан өдөр тухайн ангилал бүрээр тусгасан санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ, тэдгээрийн ангилал, дансны үнийг тодруулна.
114. УСНББОУС 29 нь анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн хөрөнгийг борлуулах боломжтой гэж ангилах, эсвэл санхүүгийн хэрэглүүрийг (хэрэв тодорхой шалгуурыг хангасан бол) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр гэж ангилахыг зөвшөөрдөг. Энэхүү шаардлагыг үл харгалзан дараах тохиолдолд гажих нөхцлүүдийг мөрддөг:
- (а) Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр борлуулах боломжтой гэж ангилахыг түүнд зөвшөөрдөг.
  - (б) УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хэрэв хөрөнгө буюу өр төлбөр нь УСНББОУС 29-ийн 10 (б)(i), 10(б)(ii), 13-р параграфт заасан, шалгуурыг хангаж байвал уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү өдөр аливаа санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахыг түүнд зөвшөөрдөг.

*Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт*

115. 116-р параграфтаар зөвшөөрснөөс бусад тохиолдолд, УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөхгүй байхыг зөвшөөрдөг шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу тухайн санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрсөн өдөр (аль түрүүнд болох өдөр) болон түүнээс хойш гарч тохиолдсон ажил гүйлгээний хувьд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 29-д заасан, үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөнө. Жишээлбэл; УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө гарч тохиолдсон ажил гүйлгээний үр дүнд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь үүсмэл бус санхүүгийн хөрөнгө буюу үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу үл хүлээн зөвшөөрсөн бол тэдгээр хөрөнгө, өр төлбөр нь дараагийн ажил гүйлгээ буюу үйл явдлын үр дүнд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаснаас бусад тохиолдолд тэдгээрийг хүлээн зөвшөөрөхгүй.

116. Өнгөрсөн ажил гүйлгээний үр дүнд үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрт УСНББОУС 29-ийг мөрдөхөд шаардлагатай мэдээллийг тэдгээр ажил гүйлгээг анх тайлагнах үед олж авсан бол 115-р параграфт заасан нөхцлийг үл харгалзан, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн сонгосон өдрөөс эхлэн УСНББОУС 29-ийн үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг буцаах горимоор мөрдөж болно.

*Хейжийн нягтлан бодох бүртгэл*

117. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) УСНББОУС 29-өөр шаардсанчлан, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь:
- (а) бүх үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжинэ; ба
  - (б) нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хөрөнгө, өр төлбөр байсан мэтээр тайлагнасан үүсмэл хэрэглүүрүүдээс үүссэн бүх хойшлогдсон олз, гарзыг устгаж цэвэрлэнэ.
118. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 29-д заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй тийм төрлийн хейжийн харилцааг (жишээлбэл; хейжийн хэрэглүүр нь мөнгөн хэрэглүүр эсвэл гаргасан опцион байх, эсвэл хейжийн зүйл нь цэвэр төлөв байдал байх хейжийн олон харилцааг) өөрийн эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа тусгахгүй. Гэвч анх удаа мөрдөж буй байгууллага нь цэвэр төлөв байдлыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хейжийн зүйл гэж сонгосон бол УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) хожуу биш хугацаанд тус байгууллага нь тэрхүү цэвэр төлөв байдлын хүрэн дэх бие даасан зүйлийг УСНББОУС-ын дагуу хейжийн зүйл гэж сонгож болно.
119. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) өмнө уг анх удаа мөрдөж буй байгууллага нь ажил

гүйлгээг хейж гэж сонгосон боловч тухайн хейж нь УСНББОУС 29-д заасан, хейжийн нягтлан бодох бүртгэлийн нөхцлүүдийг хангахгүй байвал тус байгууллага нь хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсоохын тулд УСНББОУС 29-ийн 102 ба 112-р параграфыг мөрдөнө. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) өмнө хийгдсэн ажил гүйлгээг хейж гэж буцаан сонгохгүй.

*Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт*

120. Санхүүгийн хэрэглүүрийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг 36, 38, 42-р параграфын чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг тийм санхүүгийн хөрөнгүүдтэй холбоотой байхаас бусад тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс эхлэн гүйцээх горимоор мөрдөнө. Анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийг ашигладаг бол тус байгууллага нь тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) уг үнэ цэнийн бууралтын нөхцлүүдийг мөрдөнө.
121. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл ийм чөлөөлөлт олгосон шилжилтийн үеийн нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн ба холбогдох мэдээллийг тухайн санхүүгийн тайланд зохих УСНББОУС-ын дагуу толилуулж, тодруулсан үед (аль түрүүнд болох өдөр) уг анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн, санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ буурсан гэсэн ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлнэ. Үүссэн аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн тайлант үеийн хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.
122. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөнө. Энэ нь УСНББОУС 29-ийг мөрдсөн өдөр эсвэл ийм чөлөөлөлт олгосон шилжилтийн үеийн нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу анх мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ буурсан гэсэн шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай бол холбогдох санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн зөвхөн тэр үе (аль түрүүнд болох өдөр) гэсэн үг юм. Аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд эсвэл тухайн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрч,

хэмжсэн (аль түрүүнд болох өдөр) тайлант үед хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.

### **УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга**

123. Анх удаа мөрдөж буй байгууллага нь 78-р параграфын дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн тохиолдолд тухайн зэрэгцүүлэгдэх тайлант үед санхүүгийн хэрэглүүрээс үүссэн эрсдлийн шинж төрөл ба хэмжээний талаархи мэдээллийг түүний шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланд эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд толилуулахыг уг байгууллагаас шаардахгүй.
124. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл ийм чөлөөлөлт олгосон шилжилтийн үеийн нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох санхүүгийн хэрэглүүрийг УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн үед (аль түрүүнд болох өдөр) УСНББОУС 29-ийн шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөнө.

### **УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө**

125. Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу зардал болгодог байсан боловч энэ нь УСНББОУС 31-д заасан, биет бус хөрөнгийн тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байвал уг анх удаа мөрдөж буй байгууллага нь дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжинэ. Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлж болохгүй.
126. 20-р параграфээр шаардсанчлан, анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-аар хүлээн зөвшөөрөхийг шаарддаг бүх хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу зардал болгон бүртгэдэг байсан эсэхийг үл хамааран УСНББОУС 31-д заасан, биет бус хөрөнгийн тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангадаг, дотооддоо бий болгосон аливаа биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

### **УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл**

*Холбогдох өр төлбөрийн анхны хэмжилт*

127. Анх удаа мөрдөж буй байгууллага нь төсөөлөн тооцсон өртөг ашиглан үйлчилгээний концессын хөрөнгийг хэмжих сонголт хийсэн тохиолдолд холбогдох өр төлбөрийг дараах байдлаар хэмжинэ:
- (a) Санхүүгийн өр төлбөрийн загварын дагуу хэмжих өр төлбөрийн хувьд, завал биелүүлэх хэлцэлд заасан гэрээний үлдсэн мөнгөн гүйлгээ ба УСНББОУС 32-т заасан хүүний түвшин; эсвэл



(б) Эзэмшигчид эрх олгох загварын дагуу хэмжих өр төлбөрийн хувьд, хөрөнгийн бодит үнэ цэнээс аливаа санхүүгийн өр төлбөрийг хасах ба тухайн үйлчилгээний концессын хэлцлийн үлдсэн хугацааг тусгахын тулд тохируулга хийсэн дүн.

128. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үйлчилгээний концессын хөрөнгийн үнэ цэнэ ба 127-р параграфт дурдсан, санхүүгийн өр төлбөрийн загварын дагуу хэмжсэн санхүүгийн өр төлбөрийн хоорондох аливаа зөрүүг тухайн зүйлийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн тайлант үеийн хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрч, хэмжинэ.

**УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан, УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан, УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт**

129. Хөрөнгө оруулалтын байгууллагын хяналтанд буй байгууллага байхаас бусад тохиолдолд уг хяналтанд буй байгууллага нь хяналт тавигч байгууллагаасаа хожуу анх удаа мөрдөж буй байгууллага болсон бол тэрхүү хяналтанд буй байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө дараах дүнгийн аль нэгээр өөрийн санхүүгийн тайландаа хэмжинэ:

(а) Хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд буй байгууллагыг олж эзэмшсэн улсын секторын нэгдлийн үр нөлөө ба нэгтгэлийн горимын хувьд тохируулга хийгээгүй бол тухайн хяналтанд буй байгууллагын УСНББОУС-ыг мөрдсөн өдөрт үндэслэн энэ УСНББОУС-ын дагуу тодорхойлсон ба хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдах дансны үнэ; эсвэл

(б) Энэ УСНББОУС-ын бусад параграфтаар шаардсан ба уг хяналтанд буй байгууллагын УСНББОУС-д шилжсэн өдөрт үндэслэсэн дансны үнэ. Тэдгээр дансны үнүүд нь доор нөхцөлд (а)-д дурдсан, дансны үнээс өөр байж болно:

(i) Энэхүү УСНББОУС-д заасан чөлөөлөх нөхцөл нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хамааралтай хэмжилтэнд хүргэдэг тохиолдолд.

(ii) Хяналтанд буй байгууллагын санхүүгийн тайланд ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь нэгтгэсэн санхүүгийн тайланд ашигласан бодлогоос өөр байх тохиолдолд. Жишээлбэл; хяналтанд буй байгууллага нь УСНББОУС 17-д заасан, өртгийн загварыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого болгон ашигладаг, харин эдийн засгийн нэгдмэл байгууллага нь дахин үнэлгээний загварыг ашигладаг байж болох юм.

**Мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл хамтын хяналт тавьдаг байгууллагаасаа хожуу, анх удаа мөрдөж буй байгууллага болсон хараат байгууллага**

буюу хамтарсан үйлдвэрийн хувьд дээрхтэй адил сонголтыг хийж болох юм.

130. Харин хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагаасаа (хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрээс) хожуу, анх удаа мөрдөж буй байгууллага болсон бол уг хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагын (хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн) хөрөнгө, өр төлбөрийг түүний (хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн) санхүүгийн тайланд тусгаж байсантай ижил дансны үнээр өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хэмжиж, тусгана. Гэхдээ энэ УСНББОУС-ын хүрээнд мөрдөж болох чөлөөлөлтийн нөхцлүүдийг харгалзан, нэгтгэлийн тохируулга, өмчийн аргын нягтлан бодох бүртгэлийн тохируулга, түүнчлэн хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд буй байгууллагыг (хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийг) олж эзэмшсэн улсын секторын нэгдлийн үр нөлөөний хувьд тохируулга хийсний дараах дүнгээр хэмжинэ. Үүнтэй адилаар, хяналтанд буй байгууллага нь өөрийн тусдаа санхүүгийн тайлангийн хувьд нэгтгэсэн санхүүгийн тайлангаас эрт эсвэл хожуу, анх удаа мөрдөж буй байгууллага болсон бол тус хяналтанд буй байгууллага нь энэ УСНББОУС-д мөрдөж болох нэгтгэлийн тохируулгаас бусад чөлөөлөх нөхцлүүдийг харгалзан өөрийн хөрөнгө, өр төлбөрийг эдгээр санхүүгийн тайлангийн аль алинд ижил дүнгээр хэмжинэ.

#### УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан

131. Хяналтанд буй байгууллага болох анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр оршин буй баримт материал болон нөхцөл байдлуудад үндэслэн өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага мөн эсэхээ үнэлэх ба хяналтанд буй байгууллага нэг бүрд оруулсан өөрийн хөрөнгө оруулалтыг уг аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ.

#### УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр

132. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хамтарсан үйлдвэрт оруулсан өөрийн хөрөнгө оруулалтыг хувь тэнцүүлэн нэгтгэх аргыг ашиглан нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг өмнө нь хувь тэнцүүлэн нэгтгэсэн байгууллагын хөрөнгө, өр төлбөрийн үүн дотроо, худалдан авалтын ажил гүйлгээнээс үүссэн, худалдан авсан аливаа гүүдвилийн нийт дансны үнээр хэмжинэ (УСНББОУС 40-ийг үзнэ үү).
133. 132-р параграфын дагуу тодорхойлсон, хөрөнгө оруулалтын эхний үлдэгдлийг тухайн хөрөнгө оруулалтын анх хүлээн зөвшөөрөх үеийн төсөөлөн тооцсон өртөг гэж үзнэ. Хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхээс үл

хамааран уг анх мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтыг сорьж шалгана. Үнэ цэнийн бууралтын аливаа гарзыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр хуримтлагдсан ашиг, алдагдалд тусган тохируулна.

134. Өмнө нь хувь тэнцүүлэн нэгтгэж байсан хөрөнгө, өр төлбөрийн нийт дүн нь сөрөг цэвэр хөрөнгө үүсгэх үр дүнтэй байвал уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү сөрөг цэвэр хөрөнгөтэй холбоотой хууль эрх зүйн эсвэл гэрээний бус үүрэг хүлээх эсэхээ үнэлэх бөгөөд хэрэв ийм үүрэг хүлээхээр бол холбогдох өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь сөрөг цэвэр хөрөнгөтэй холбоотойгоор хууль эрх зүйн эсвэл гэрээний бус үүрэг хүлээхгүй гэж дүгнэсэн бол холбогдох өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй боловч УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр хуримтлагдсан ашиг, алдагдлын дүнг тохируулна. Анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр өөрийн хамтарсан үйлдвэрийн хүлээн зөвшөөрөөгүй, хуримтлагдсан гарзын хамтаар энэ тухай тодруулга хийнэ.

## Тодруулга

135. Энэ УСНББОУС-ын шаардлагуудад нийцсэн санхүүгийн тайлан бүхий уг анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулга ба аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөх шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон заалтуудын давуу талыг ашиглахаас гадна энэ УСНББОУС-д нийцсэн талаархи бүрэн тодорхой мэдэгдлийг санхүүгийн тайлангийн тодруулгадаа тусган оруулна. Ийм мэдэгдэлд тухайн санхүүгийн тайлан нь аккруэл суурт УСНББОУС-тай бүрэн нийцээгүй гэсэн мэдэгдлийг дагалдуулан тусгаж болно.
136. Анх удаа мөрдөж буй байгууллага нь энэ УСНББОУС-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд дараах зүйлсийг тодруулна:
- (а) Санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга болон аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөх, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигласан хэмжээ;
  - (б) Санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга болон аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөхгүй, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигласан хэмжээ.
137. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын хувьд үнэн зөв толилуулга болон аккруэл суурт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх, энэ УСНББОУС-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл, заалтын давуу талыг ашигладаг тохиолдолд дараах зүйлсийг тодруулна:

- (а) **Зохих УСНББОУС-ын шаардлагуудын дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх, хэмжих, толилуулах, тодруулахад чиглэгдсэн явц өрнөл;**
  - (б) **Зохих УСНББОУС-ын шаардлагуудтай нийцээгүй нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал;**
  - (в) **Өмнөх тайлант үед хэмжээгүй, толилуулаагүй, тодруулаагүй боловч одоо хүлээн зөвшөөрч, хэмжиж, толилуулж, тодруулж байгаа хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал;**
  - (г) **Тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн аливаа тохируулгын шинж төрөл ба дүн;**
  - (д) **Зохих УСНББОУС-ын шаардлагуудыг хэрхэн, хэзээ бүрэн даган мөрдөх талаархи мэдэгдэл.**
138. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэхгүй байхыг зөвшөөрдөг шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг ба/буюу 55-р параграфт дурдсан, хяналтанд буй байгууллага, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь оролцооны хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн хувьд гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийг мөрддөг тохиолдолд тус байгууллага нь тухайн тайлант үед устгаж цэвэрлэсэн үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардал, “дээш чиглэсэн” ба “доош чиглэсэн” ажил гүйлгээний шинж төрлийг тодруулна.**
139. **58 ба 62-р параграфт дурдсан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл, заалтыг мөрдсөний улмаас уг анх удаа мөрдөж буй байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулах боломжгүй байгаа тохиолдолд дараах зүйлийг тодруулна:**
- (а) **Тухайн санхүүгийн тайлан, хараат байгууллагад оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог нэгтгэсэн санхүүгийн тайлан байдлаар толилуулах боломжгүй байгаа шалтгаан;**
  - (б) **Анх удаа мөрдөж буй байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг хэзээ толилуулах боломжтой талаархи мэдэгдэл.**
140. **135 ба 139-р параграф дахь тодруулгын шаардлага нь шилжилтийн хугацаанд уг анх удаа мөрдөж буй байгууллага өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг зохих УСНББОУС-ын шаардлагуудтай нийцүүлэх явц өрнөлийг санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар шалган тодорхойлоход тэдэнд тусалдаг.**

#### **УСНББОУС-д шилжсэн талаархи тайлбар**

141. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (а) **УСНББОУС-ыг мөрдсөн өдөр;**

- (б) Нягтлан бодох бүртгэлийн өмнөх сууриас УСНББОУС-д шилжилт нь түүний тайлагнасан санхүүгийн байдал, хэрэв тохиромжтой бол, санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээнд хэрхэн нөлөөлсөн талаархи мэдээлэл ба тайлбар.

### Тохируулгын тайлан

142. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлангийн тодруулгад дараах зүйлсийг толилуулна:**

- (а) Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан цэвэр хөрөнгө/өмчийг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдэл болгох тохируулгын тайлан;
- (б) Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан ашиг, алдагдлыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх ашиг, алдагдлын эхний үлдэгдэл болгох тохируулгын тайлан.

**Өөрийн өмнөх санхүүгийн тайландаа нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг мөрдөж байсан, анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм тохируулгын тайланг толилуулах шаардлагагүй юм.**

143. 142-р параграфын дагуу толилуулсан тохируулгын тайлан нь эхлэлийн санхүүгийн байдлын тайлан түүнчлэн, хамааралтай бол аккруэл суурьт УСНББОУС-ын дагуу толилуулсан, санхүүгийн үр дүнгийн дахин илэрхийлсэн зэрэгцүүлэгдэх тайланд хийсэн материаллаг залруулгыг ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгох тоон болон чанарын хангалттай дэлгэрэнгүй мэдээллээр хангана. Санхүүгийн тайлангийн хамтаар гаргасан, олон нийтэд танилцуулдаг бусад баримт бичигт хүүрнэсэн тайлбар оруулсан тохиолдолд тэдгээр баримт бичигт хийгдэх харилцан лавлагааг санхүүгийн тайлангийн тодруулгад тусган оруулна.
144. Хэрэв байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу алдаа гаргаснаа олж мэдсэн бол 142-р параграфт дурдсан, тохируулгын тайлан нь тэрхүү алдааны засварлалтыг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс ялган харуулах хэрэгтэй.
145. **Хэрэв байгууллага нь өмнөх тайлант үеүдэд санхүүгийн тайланг толилуулаагүй байсан бол шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайландаа энэ тухай тодруулга хийнэ.**
146. **Анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн зүйлийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг 36-43-р параграфын чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд уг өмнө тайлагнасан санхүүгийн тайланд тэдгээр зүйлийг тусган оруулаагүй бол тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжих байсан зүйлсийн тохируулгын тайланг санхүүгийн тайлангийн тодруулгын нэг хэсэг**

**байдлаар толилуулна. Энэ УСНББОУС-ын дагуу шинэ зүйлсийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн тайлант үе бүрд тохируулгын тайланг толилуулна.**

147. Анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн зүйлийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг шилжилтийн үеийн нэг буюу хэд хэдэн чөлөөлөх нөхцлүүдийг ашигладаг тохиолдолд 146-р параграфын дагуу толилуулсан тохируулгын тайлан нь тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн зүйлийг ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгох хангалттай дэлгэрэнгүй мэдээллээр хангана. **Энэ УСНББОУС-ын дагуу шинэ зүйлсийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн тайлант үе бүрд уг тохируулгын тайлан нь өмнө тайлагнасан санхүүгийн байдлын тайлан түүнчлэн, хамааралтай бол өмнө тайлагнасан санхүүгийн үр дүнгийн тайлан бүрд хийсэн залруулгыг тайлбарласан байна.**

**Бараа материал, Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, Үндсэн хөрөнгө, Биет бус хөрөнгө, Санхүүгийн хэрэглүүр, Үйлчилгээний концессын хөрөнгөнд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах үед хийх тодруулга**

148. Анх удаа мөрдөж буй байгууллага нь бараа материал, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, санхүүгийн хэрэглүүр, үйлчилгээний концессын хөрөнгийн хувьд бодит үнэ цэнийг эсвэл 64, 67, 70-р параграфт дурдсан, хувилбар үнийг төсөөлөн тооцсон өртөг болгон ашигладаг бол өөрийн санхүүгийн тайландаа дараах зүйлсийг тодруулна:
- (a) Тэдгээр бодит үнэ цэнэ эсвэл төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлоход харгалзан үзсэн хувилбар үнүүдийн нийт дүн;
  - (б) Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн дансны үнэд хийсэн тохируулгын нийт дүн;
  - (в) Төсөөлөн тооцсон өртгийг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр эсвэл шилжилтийн тайлант үеийн туршид тодорхойлсон эсэх.

**Хяналтанд буй байгууллага, Хамтарсан үйлдвэр буюу Хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах үед хийх тодруулга**

149. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хяналтанд буй байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтын хувьд өөрийн эхлэлийн санхүүгийн байдлын тайланд, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтын хувьд түүний тусдаа санхүүгийн тайланд бодит үнэ цэнийг төсөөлөн тооцсон өртөг байдлаар ашигладаг бол тусдаа санхүүгийн тайланд дараах зүйлсийг тодруулна:
- (a) Төсөөлөн тооцсон өртөг нь бодит үнэ цэнэ байх тэдгээр хөрөнгө оруулалтын төсөөлөн тооцсон өртгийн нийт дүн;

(б) Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн дансны үнэд хийсэн тохируулгын нийт дүн.

150. Чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгүүдийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих өдөр (аль түрүүнд болох өдөр) хүртэл шинэ зүйлсийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн тайлант үе бүрд 148 ба 149-р параграфтаар шаардсан тодруулгын шаардлагуудыг тодруулна.

#### Шилжилтийн үед УСНББОУС-ын тодруулгын шаардлагуудаас чөлөөлөх

151. Анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дуусах ба/буюу холбогдох зүйлсийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл УСНББОУС 1, УСНББОУС 18 ба зохих УСНББОУС-д шаардсан, ийм зүйлсэд хамаарах аливаа холбогдох толилуулгын болон тодруулгын шаардлагуудыг мөрдөх албагүй юм.

152. 151-р параграфт заасан, шилжилтийн нөхцлөөс үл хамааран анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 1, УСНББОУС 18 ба зохих УСНББОУС-аар шаардсан мэдээллийг боломжтой болсон тэр даруйд тодруулахыг дэмжинэ.

#### Шилжилтийн нөхцөл

153. Анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт бусад УСНББОУС-д заасан, одоо хүчин төгөлдөр байгаа шилжилтийн нөхцлүүдийг мөрддөг бол тус байгууллага нь тэрхүү шилжилтийн нөхцлийн хугацаа дуусах ба/буюу холбогдох зүйлсийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл тэдгээр шилжилтийн нөхцлүүдийг мөрдсөн хэвээр байна. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь энэ УСНББОУС-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүдийг мөрдөх сонголт хийсэн бол аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөхдөө ашигласан чөлөөлөлтийн хугацаа нь энэ УСНББОУС-д заасан чөлөөлөлтийн хугацаанаас илүү урт байж болохгүй.

#### Хүчин төгөлдөр болох хугацаа

154. Анх удаа мөрдөж буй байгууллагын УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеийг хамрах бол тус байгууллага нь энэ Стандартыг мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

154A. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 7, 8-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу

түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 154Б. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 36, 102, 104, 105-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 106, 107-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.
- 154В. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 86, 129, 130, 132-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 62А-62В параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.



**Хавсралт А**

**Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт**

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Оршил

- ДҮ1. УСНББОУС 33-ыг боловсруулахаас өмнө, УСНББОУС-ын анх удаа мөрдөлтөөс үүсэх асуудлуудыг зохицуулах Стандарт байгаагүй. Иймээс УСНББОУС3 нь аккруэл суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг мөрдөхдөө байгууллагуудын ашиглах иж бүрэн зарчмуудыг боловсруулахын тулд энэ төслийг 2011 оны 6 дугаар сард баталсан.
- ДҮ2. Энэхүү УСНББОУС нь Хэрэгжүүлэх заавар удирдамжтай боловч УСНББОУС-ын анх удаа мөрдөлтийн талаархи илүү дэлгэрэнгүй, практик заавар удирдамж боловсруулах нь энэ төслийн цар хүрээнд хамаардаггүй. УСНББОУС3-ийн үзэл бодлоор бол, анх удаа мөрдөлттэй холбоотой тодорхой асуудлууд нь нэг улсаас нөгөө улсад өөр байх магадлалтай бөгөөд анх удаа мөрдөж буй байгууллагуудын хувьд эхлэлийн цэг нь тэдгээрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх сууриас хамааран ялгаатай байх учраас бие даасан улсууд нь анх удаа мөрдөж буй байгууллагууд аккруэл суурьт УСНББОУС-д шилжихэд туслах хэрэгжүүлэлтийн нэмэлт заавар удирдамжийг боловсруулахад үүрэг гүйцэтгэх шаардлагатай байдаг.
- ДҮ3. Тайлагналын өөр үзэл баримтлалын дагуу мөнгөн сууриас эсвэл аккруэл сууриас шилжилтийг, эсвэл нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь буюу аккруэл суурийн тохируулсан хувилбарыг энэхүү УСНББОУС-д авч үздэг. Иймээс уг төсөл нь СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр биш гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ4. Гэвч энэ УСНББОУС-ыг боловсруулахдаа УСНББОУС3 нь СТОУС 1, *Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг Анх Удаа Мөрдөх*-д тусгасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд, түүнчлэн одоо мөрдөж буй УСНББОУС-д заасан, шилжилтийн үеийн нөхцлүүдийг харгалзан үзсэн.
- ДҮ5. Энэ УСНББОУС нь СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр биш учраас шилжилтийн үеийн бүх нөхцлүүд болон чөлөөлөлтүүдийг нэг тунхаглалд тусган оруулах хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 нь энэ УСНББОУС-ыг боловсруулах үедээ хүлээн зөвшөөрсөн. Шилжилтийн нөхцлүүд болон чөлөөлөлтүүдийг уг Стандартад тэр чигт нь хамааруулвал санхүүгийн тайлан бэлтгэн гаргагч нарыг будлихад хүргэж болох учраас УСНББОУС3 нь СТОУС 1-тэй харьцуулснаар тэдгээр шилжилтийн нөхцлүүд ба чөлөөлөлтүүдийг хавсралт байдлаар тусган оруулах хэрэггүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

- ДҮ6. Энэ УСНББОУС-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүдийг мөрдсөн үеэс эдгээр нь УСНББОУС-ууд дахь шилжилтийн үеийн олон нөхцлүүдийг орлох юм.
- ДҮ7. УСНББОУСЗ нь шинэ тунхаглал гаргах тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллагад чөлөөлөлт олгох энэхүү УСНББОУС-д заасан, чөлөөлөлтийн тодорхой нөхцлүүдийг харгалзан үзнэ. Аккруэл суурьт УСНББОУС-ыг угаасаа мөрддөг байгууллагуудад хамаарах шилжилтийн нөхцлүүдийг тухайн боловсруулсан шинэ тунхаглалуудад тусган оруулна.

### Цар хүрээ

- ДҮ8. Байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдсөн үед болон аккруэл суурьт УСНББОУС-д шилжсэн тайлант үеийн туршид энэ УСНББОУС-д заасан, шилжилтийн үеийн нэг буюу хэд хэдэн чөлөөлөлт болон нөхцлүүдийг мөрдсөн тохиолдолд энэхүү УСНББОУС-ыг мөрдөнө. Энэхүү УСНББОУС нь анх удаа мөрдөж буй байгууллагыг өөрийн санхүүгийн тайлангаа толилуулахаас чөлөөлдөг бөгөөд шилжилтийн үед зарим нөхцлөөс сайн дураар чөлөөлөгдөхийг зөвшөөрдөг.
- ДҮ9. Энэ УСНББОУС нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр хүчин төгөлдөр байгаа УСНББОУС нэг бүрийг мөрдөхийг байгууллагаас шаарддаг боловч санхүүгийн тайлан хэрэглэгчдийн хүртэх өгөөж нь тэдгээр шаардлагыг даган мөрдөх өртөг зардлаас бага байх тохиолдолд зарим талбарын хувьд шаардлагуудаас хязгаарлагдмал хэмжээнд чөлөөлөгдөх боломж олгодог. Зарим УСНББОУС-ыг ялангуяа, өнгөрсөн нөхцөл байдлын талаар удирдлагын шүүн тунгаалт хийхийг шаардах тохиолдолд буцаах горимоор мөрдөхийг хориглодог.
- ДҮ10. Аккруэл суурьт УСНББОУС-д шилжих хугацаанд энэ УСНББОУС-д заасан, чөлөөлөх нөхцлүүд нь одоо мөрдөж байгаа аккруэл суурьт УСНББОУС-ын зарим шаардлагуудаас илүү давуутай байж болно.
- ДҮ11. Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь уг анх удаа мөрдөж буй байгууллага аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөх сонголт хийсэн тайлант үеийн эхлэл юм. Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөх нэг буюу хэд хэдэн сайн дураар чөлөөлөгдөх нөхцөл буюу заалтыг мөрдөх сонголт хийсэн бол анх удаа мөрдөж буй байгууллага нь шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг тэрхүү шилжилтийн хугацаанд толилуулна. Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь арай эрт байж болох боловч УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-д шаардсанчлан, аккруэл суурьт УСНББОУС-д нийцсэн гэж мэдэгдэхийн тулд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт бусад УСНББОУС-д заасан, хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулга, тодруулгын шаардлагуудыг тухайн шилжилтийн үеийн эцэст даган мөрдөх ёстой.

ДҮ12. Харин аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулга болон аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөх нэг буюу хэд хэдэн чөлөөлөлт буюу нөхцлийг мөрдөхгүй байх сонголт хийсэн бол анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг тэрхүү шилжилтийн хугацаанд толилуулж болно. УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан гэдэг нь тэдгээр санхүүгийн тайлан аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн талаархи бүрэн тодорхой мэдэгдлийг уг анх удаа мөрдөж буй байгууллага гаргасан тийм санхүүгийн тайлан юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулга болон аккруэл суурт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх энэ УСНББОУС-д заасан, чөлөөлөх нөхцлүүдийг мөрддөггүй бол аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөний дараах түүний анхны санхүүгийн тайлан нь мөн түүний УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан байж болох юм.

**Шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүдийг боловсруулах ба үнэлэх шалгуурыг боловсруулан гаргах**

ДҮ13. Энэхүү УСНББОУС-ын шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүдийг боловсруулахдаа УСНББОУСЗ нь аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр ба шилжилтийн үед хэрэглэгчийн мэдээллийн хэрэгцээ ямар байх магадлалтай гэдэгт үндэслэн цогц шалгуурыг боловсруулсан бөгөөд *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал (Онолын Үзэл Баримтлал)-ын Бүлэг 2-д* харуулсан. *Онолын Үзэл Баримтлал-ын Бүлэг 3-т* заасанчлан, Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналд тусгасан мэдээллийн чанарын шинжүүд ба хязгаарлалтуудын үнэлгээний дагуу шилжилтийн нөхцлүүдийг үнэлэхдээ эдгээр шалгуурыг ашигласан. Эдгээр үнэлгээний үр дүнг ДҮ14-ДҮ19-р параграфт тусган оруулсан.

ДҮ14. Анх удаа мөрдөж буй байгууллагын эхлэлийн санхүүгийн байдлын тайланд тавигдах шаардлагуудыг боловсруулах ба шилжилтийн үеийн чөлөөлөлтийг харгалзан үзэхдээ, УСНББОУСЗ нь *Онолын Үзэл Баримтлал-ын Бүлэг 2-т* заасан, санхүүгийн тайлангийн зорилгыг лавлагаа болгодог.

ДҮ15. Санхүүгийн тайлангийн зорилго нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгоор мэдээллийг бүрдүүлэхэд янз бүрийн хэрэглэгчдэд ач холбогдолтой тухайн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, санхүүгийн байдлын өөрчлөлтийн талаархи мэдээллээр хангах явдал гэж *Онолын Үзэл Баримтлалын Бүлэг 2-т* заасан.

ДҮ16. Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (НЗСТ)-д тусгасан, мэдээллийн чанарын шинжүүдийг *Онолын Үзэл Баримтлалын Бүлэг 3-т* бас тодорхойлсон. Эдгээр чанарын шинжүүд нь хамааралтай байх, үнэн зөв толилуулах, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх явдал юм. НЗСТ-д тусгасан мэдээлэлд тавигдах хязгаарлалтууд нь материаллаг байдал ба өртөг-өгөөжийн шалгуур юм.

**Шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүдийг боловсруулахад ашигласан шалгуур**

*Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцэлт*

- ДҮ17. Санхүүгийн тайлан нь УСНББОУС-тай нийцдэг бол байгууллага нь ийм нийцлийн талаархи бүрэн тодорхой мэдэгдлийг уг санхүүгийн тайлангийн тодруулгад оруулахыг УСНББОУС 1-д шаардсан байдаг. Санхүүгийн тайлан нь УСНББОУС-ын бүх шаардлагуудтай нийцсэн биш л бол байгууллага нь уг санхүүгийн тайланг УСНББОУС-тай нийцсэн гэж илэрхийлж болохгүй. УСНББОУС-ын анх удаа мөрдөлттэй холбоотой асуудлуудын нарийн төвөгтэй байдлын улмаас зарим тохиолдолд чөлөөлөлт олгох хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Гэвч зарим чөлөөлөлт нь уг анх удаа мөрдөж буй байгууллагын санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөнө гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ18. Анх удаа мөрдөж буй байгууллагын санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулгад нөлөөлөх ба үл нөлөөлөх шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүдийг ялган тодорхойлох хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Стандартыг ийм маягаар бүтэцчлэн ангилах нь шилжилтийн хугацаанд тэдгээрийн санхүүгийн тайланд шилжилтийн үеийн янз бүрийн нөхцлүүд ба чөлөөлөлтүүдийн үзүүлэх үр нөлөөний талаар санхүүгийн тайлан бэлтгэгч нарт илүү сайн ойлголт өгнө гэдгийг УСНББОУСЗ мөн хүлээн зөвшөөрсөн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь энэхүү УСНББОУС-д заасан, зарим чөлөөлөлтийг мөрдсөн бол УСНББОУС 1-ээр шаардсанчлан, тэрээр аккруэл суурьт УСНББОУС-д нийцсэн гэж мэдэгдэх боломжгүй болохыг анхаарах хэрэгтэй гэж УСНББОУСЗ нь ингэж ялган тодорхойлсны дараа мэдэгдсэн.
- ДҮ19. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх, чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигласан бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах буюу холбогдох зүйлсийг хүлээн зөвшөөрч, хэмжих ба/буюу холбогдох мэдээллийг тухайн санхүүгийн тайланд зохих УСНББОУС-ын дагуу толилуулж, тодруулах хүртэл (аль түрүүнд болох өдрөөр) уг байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн талаар бүрэн тодорхой мэдэгдлийг гаргаж болохгүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ20. *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартыг Анх Удаа Мөрдөх* гэсэн энэхүү санал болгосон УСНББОУС-ын талаархи саналуудыг хүлээн авсны дараа, УСНББОУСЗ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх уг анх удаа мөрдөж буй байгууллагын чадвар боломжид тэдгээр шилжилтийн үеийн чөлөөлөлтүүд болон нөхцлүүд ямар хэмжээгээр нөлөөлөхийг үнэлэх үүднээс тус байгууллага шүүн тунгаалт хийх хэрэгтэй гэдгийг тодруулан заахыг хүлээн

зөвшөөрсөн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөх шилжилтийн үеийн нэг буюу хэд хэдэн чөлөөлөлтүүд болон нөхцлүүдийг мөрдөх сонголт хийсэн тохиолдолд уг чөлөөлөгдсөн зүйл, ажил гүйлгээ, үйл явдлын хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилт нь бүхэлдээ тухайн санхүүгийн тайлангийн хувьд материаллаг бус учраас тэрхүү анх мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулсан гэж дүгнэсэн хэвээр байж болно. Мөрдсөн шилжилтийн үеийн чөлөөлөлт ба нөхцөл нь бүхэлдээ тухайн санхүүгийн тайлангийн хувьд материаллаг эсэхийг үнэлэх шүүн тунгаалтыг уг анх удаа мөрдөж буй байгууллагын тодорхой нөхцөл байдалд үндэслэн хийх шаардлагатай.

ДҮ21. Анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх шилжилтийн үеийн нэг буюу хэд хэдэн чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг анхны тайлант үеийн эцэст толилуулсан санхүүгийн тайланг шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан гэж нэрлэх хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Яагаад гэвэл, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөх чөлөөлөх нөхцлүүдийг мөрдөх үедээ УСНББОУС-д нийцсэн гэсэн бүрэн тодорхой мэдэгдлийг гаргах боломжгүй байдаг.

ДҮ22. Аккруэл суурьт УСНББОУС-д шилжих явцад холбогдох мэдээллээр хангахын тулд уг анх удаа мөрдөж буй байгууллагын ашигласан шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон нягтлан бодох бүртгэлийн өмнөх сууриас аккруэл суурьт УСНББОУС-д хэрхэн шилжсэн талаар хэрэглэгчдэд мэдээлэх тодруулгыг хийнэ.

ДҮ23. Анх удаа мөрдөж буй байгууллагын аккруэл суурьт УСНББОУС-д нийцсэн явцын тайлагналыг үнэлэх боломжтой болохын тулд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг уг анх удаа мөрдөж буй байгууллагын аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлд шилжилтийн нэг хэсэг байдлаар боловсруулах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Ийм төлөвлөгөөний дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх, хэмжих, толилуулах, тодруулахад чиглэгдсэн явц өрнөлийн талаархи тодруулга нь уг байгууллага зохих бүх УСНББОУС-ын шаардлагуудыг хэзээ, хэрхэн бүрэн даган мөрдөх санаа зорилготой байгааг тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар ойлгоход ач холбогдолтой мэдээллээр тэднийг хангах юм.

### **Анх удаа мөрдсөн талаархи мэдээллийн толилуулга**

*Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараа, зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах*

ДҮ24. УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-д заасан, одоо байгаа шилжилтийн нөхцлүүд нь УСНББОУС-ын дагуу аккруэл нягтлан бодох бүртгэлийг анх удаа мөрдсөн тухайн санхүүгийн тайлангийн хувьд

зэрэгцүүлэгдэх мэдээллийг шаарддаггүй тул УСНББОУС-ыг мөрдсөн өдөр зэрэгцүүлэгдэх мэдээлэл шаардлагатай эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн.

ДҮ25. Өртөг-өгөөжийн шалгуурыг харгалзан үзсэнээр, УСНББОУСЗ нь аккруэл суурьт УСНББОУС-ын мөрдөлтийг дэмжихийн тулд зэрэгцүүлэгдэх мэдээллийн толилуулгын хувьд УСНББОУС 1-д заасан, одоогийн арга хандлагыг хэвээр хадгалахаа мэдэгдсэн. Иймээс энэхүү УСНББОУС нь өөрийн шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд зэрэгцүүлэгдэх мэдээллийг уг анх удаа мөрдөж буй байгууллага тусгах шаардлага оруулахгүй байснаар зөвхөн зэрэгцүүлэгдэх мэдээллээс чөлөөлөгдөхийг дэмждэг.

ДҮ26. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээлэл толилуулахгүй байх сонголт хийсэн тохиолдолд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг анх удаа мөрдөж буй байгууллагын шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан хамгийн наад зах нь, нэг санхүүгийн байдлын тайлан ба эхлэлийн санхүүгийн байдлын тайланг агуулсан байх хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

ДҮ27. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээлэл толилуулах сонголт хийсэн тохиолдолд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн өмнөх тайлант үеийн эхний байдлаар уг анх удаа мөрдөж буй байгууллага нь өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл бүхий нэг санхүүгийн байдлын тайлан ба эхлэлийн санхүүгийн байдлын тайланг толилуулах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

ДҮ28. Чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацааг ашиглах нь зэрэгцүүлэгдэх мэдээллийн толилуулгад бас нөлөөлдөг тул уг анх удаа мөрдөж буй байгууллага нь зөвшөөрөгдсөн аливаа шилжилтийн хугацааны давуу талыг ашигладаг тохиолдолд тус байгууллага нь тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн зүйлсийн талаархи мэдээлэл бэлэн боломжтой байгаа бол аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн дараах жилийн хувьд зэрэгцүүлэгдэх мэдээллийг зөвхөн залруулах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Иймээс мэдээлэл бэлэн боломжтой байгаа зөвхөн тэр хэмжээгээр зэрэгцүүлэгдэх мэдээллийг буцаах горимоор залруулна.

ДҮ29. УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлангаа толилуулсны дараа уг анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулгатай холбоотой УСНББОУС 1-ийн шаардлагуудыг дагаж мөрдөнө.

*Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараа, тохируулгын тайланг толилуулах*

ДҮ30. УСНББОУС-ын анх удаа мөрдөлттэй холбоотойгоор санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ямар мэдээлэл ач холбогдолтой байхыг харгалзан үзсэнээр, УСНББОУСЗ нь шилжилтийн үеийн УСНББОУС-д

нийцсэн санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлангийн тодруулгад тохируулгын тайланг тугсан толилуулах хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Тохируулгын тайлангийн толилуулга нь уг анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу толилуулсан мэдээлэл ба УСНББОУС-ыг ашиглан бэлтгэсэн мэдээллийн хоорондох чухал холбоог харуулдаг. Тохируулгын тайлангийн зорилго нь аккруэл суурьт УСНББОУС-ын шаардлагуудтай нийцүүлэхийн тулд хийх тохируулга, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн өмнөх сууриас УСНББОУС-д шилжилт нь уг анх удаа мөрдөж буй байгууллагын тайлагнасан санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд хэрхэн нөлөөлөхийг үлгэрчлэн харуулах явдал юм. Ийм мэдээлэл нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг.

- ДҮ31. УСНББОУСЗ нь толилуулж болох хоёр төрлийн тохируулгын тайланг авч үзсэн. Эхний тохируулга нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн байдлаарх эхлэлийн үлдэгдлийг тохируулдаг. Хоёр дахь тохируулга нь уг анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу бэлтгэсэн гаргасан хамгийн сүүлийн, жилийн санхүүгийн тайланд толилуулсан хамгийн сүүлийн тайлант үеийн эцсээрх дүнг тохируулдаг.
- ДҮ32. Хоёр дахь тохируулгын тайлан нь хэт төвөгтэй бөгөөд түүнийг толилуулах өртөг зардал нь үр өгөөжөөс давж илүү гарна гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Мөн түүнчлэн, хэрэглэгчид нь ийм тохируулгын тайланг ашиглах магадлал багатай бөгөөд уг мэдээлэл нь урьдчилан таамаглах үнэ цэнэгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.
- ДҮ33. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан эцсийн үлдэгдлээ УСНББОУС-д нийцсэн эхлэлийн санхүүгийн байдлын тайлан дахь цэвэр хөрөнгө/өмчтэй тохируулах тийм тохируулгын тайланг зөвхөн толилуулахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Энэ мэдээллийг шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулах хэрэгтэй.
- ДҮ34. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага өмнө нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг мөрдөж байсан бол цэвэр хөрөнгө/өмчийг толилуулахгүй. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь нь мөнгөн суурь бол тохируулгын тайлан толилуулах шаардлагагүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ35. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтээс чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг шилжилтийн тайлант үеийн туршид хамааралтай, ойлгомжтой, зэрэгцүүлэгдэх гэсэн чанарын шинжүүдийг хангахын тулд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-д шилжих явц дахь өөр өөр өдрүүдээр тохируулгын тайланг толилуулахыг түүнээс шаардах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн.



ДҮ36. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зөвшөөрөгдсөн аливаа шилжилтийн хугацааны давуу талыг ашигладаг тохиолдолд тус байгууллага нь өмнө тайлагнасан санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрөөгүй ба/буюу хэмжээгүй байсан боловч тухайн тайлант үед хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн зүйлсийн тохируулгын тайлаг толилуулах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн зүйлс ба эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн зүйлсийн хоорондох зөрүүг тайлбарлахын тулд толилуулсан тохируулгын тайлангаас гадна энэхүү тохируулгын тайланг толилуулах хэрэгтэй.

*Анх удаа мөрдөж буй байгууллагын санхүүгийн тайланд төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлсэн мэдээллийг толилуулах*

ДҮ37. Аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөний дараа, төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлсэн мэдээлэл толилуулахыг уг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаардах хэрэгтэй эсэх, ийм мэдээлэл нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн.

ДҮ38. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөний дараа өөрийн төсвийг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн сууриар бэлтгэдэг бол түүний шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланд ийм зэрэгцүүлэлтийг толилуулах нь төвөгтэй байж болох юм гэж УСНББОУСЗ үзсэн. Гэвч ийм зэрэгцүүлэлт нь УСНББОУС-ын онцлог шинж бөгөөд хариуцлагатай байдал, шийдвэр гаргалтанд дэмжлэг үзүүлэх тул түүнийг уг анх удаа мөрдөж буй байгууллагын санхүүгийн тайланд тусган оруулахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн.

*Анх удаа мөрдөж буй байгууллагын санхүүгийн тайланд мөнгөн гүйлгээний тайланг толилуулах*

ДҮ39. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацааг ашиглах сонголт хийсэн тохиолдолд мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэлтийн хувьд шилжилтийн үеийн чөлөөлөлт ба нөхцлүүд олгох эсэхийг харгалзан үзэхийг Стандартын төсөлд санал авах явцад хариулт өгсөн хүмүүс нь УСНББОУСЗ-өөс хүссэн. Тэдгээр хариулт өгсөн хүмүүс нь санхүүгийн байдлын тайлан иж бүрэн биш байхад мөнгөн гүйлгээний тайланг толилуулах нь тохиромжгүй гэж мэдэгдсэн.

ДҮ40. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд (а) мөнгөн орлогын гүйлгээний эх үүсвэр; (б) тайлант үеийн туршид мөнгийг зарцуулсан зүйлс; (в) тухайн тайлант үеийн эцэс дэх мөнгөний үлдэгдлийн талаархи мэдээлэл шаардлагатай хэвээр байх тул шилжилтийн хугацаанд ямар нэг чөлөөлөх нөхцөл олгохгүй гэсэн өөрийн өмнөх шийдвэрийг УСНББОУСЗ батлан илэрхийлсэн.

**Аккруэл суурт УСНББОУС ба Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн Тайлагналын уялдаа**

ДҮ41. Энэ Стандартын зорилго нь аккруэл суурт УСНББОУС-д нийцсэн нягтлан бодох бүртгэлийн зохих эхлэлийн цэгийг бүрдүүлэх явдал учраас энэ нь анх удаа мөрдөж буй байгууллагыг ЗГСС-ын тайлагнал ба аккруэл суурт УСНББОУС-ын хоорондох уялдааны талаархи тусгай заавар удирдамжаар хангахгүй юм. УСНББОУСЗ-ийн цогц тунхаглалуудын хүрээнд ЗГСС-тай уялдуулах сонголтуудын талаархи заавар удирдамжийг УСНББОУСЗ нь өөрийн Зөвлөлдөх Баримт Бичиг, “УСНББОУС ба Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн Тайлагналыг Уялдуулах Заавар: Нийцүүлэлт ба Удирдлагаар дамжуулан Ялгаатай Талуудыг Шийдвэрлэлт”-д илүү тодорхой авч хэлэлцсэн. Аккруэл суурт УСНББОУС-ын анх удаа мөрдөлтөнд Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС)-ыг уялдуулах бодлогыг сонгосноор уг анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн ЗГСС-ын тайлангуудад тусган оруулах мэдээг өндөр чанартайгаар, цаг хугацаанд нь бэлтгэх боломж бүрдүүлэх юм.

**Үнэн зөв толилуулга ба аккруэл суурт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлдөг чөлөөлөх нөхцлүүд**

*Санхүүгийн бус хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, ангилалтай холбоотой шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд*

ДҮ42. Байгууллага нь УСНББОУС-ыг анх мөрдөх үед түүний хяналтанд байгаа бүх хөрөнгийн оршин байдлын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй бөгөөд эдгээр хөрөнгийг тайлагнахын тулд зохих бүртгэлүүдийг олж авах, эмхлэн бүрдүүлэхэд тодорхой хугацаа шаардлагатай байж болох юм. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг өмнө нь мөрддөггүй байсан байгууллагад хамааралтай тул уг байгууллага нь ийм хөрөнгүүдийг УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөх, хэмжих ба/буюу ангилахад нилээд хүчин чармайлт шаардагдах магадлалтай юм.

ДҮ43. Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд анх удаа мөрдөж буй байгууллагад олговол зохих чөлөөлөлтийг харгалзан үзсэнээр УСНББОУСЗ нь одоогоор УСНББОУС 17-д таван жилийн чөлөөлөлтийн хугацаа байна гэж дүгнэсэн. Өөрийн шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг гаргахын өмнө, УСНББОУС-ын мөрдөлтөнд бэлтгэхэд байгууллагуудыг дэмжин урамшуулахын тулд УСНББОУСЗ нь гурван жилээс илүүгүй чөлөөлтийн хугацааг зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн. Байгууллагууд нь энэхүү УСНББОУС-аар олгосон чөлөөлөлтийн хугацаанд зөвхөн найдах бус, харин аккруэл суурт УСНББОУС-д шилжихэд урьдчилан сайн бэлтгэх хэрэгтэй тул УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол гурван жилийн шилжилтийн хугацаа нь удирдан зохицуулах илүү боломжтой бөгөөд УСНББОУС-д нийцсэн гэж тэдгээр байгууллагууд мэдэгдэх боломжгүй байх хугацааг богиносгох юм.

- ДҮ44. Өөрсдийн шилжилтийн хугацааг тогтоохыг улс орон бүрд зөвшөөрөхийн оронд, энэ УСНББОУС-д чөлөөлөлтийн хугацааг зааж өгөх нь улс орнуудын хоорондох үл нийцлийг багасгана гэж УСНББОУСЗ үзсэн. Мөн санхүүгийн тайлангийн итгэл үнэмшилтэй ба зэрэгцүүлэгдэх байдал нь шилжилтийн хугацаанд сайжрах юм.
- ДҮ45. Энэхүү УСНББОУС-д заасан чөлөөлөлтийн нөхцөл нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөх иж бүрэн замын зураглал биш, харин мөрдөх үйл явцын эцсийн үе шат гэж ойлгох хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Энэ УСНББОУС-д заасан, гурван жилийн чөлөөлөлтийн хугацаа нь аккруэл суурьт УСНББОУС-д шилжих эцсийн хөрвүүлэлтэнд туслахын тулд уг анх удаа мөрдөж буй байгууллагад чөлөөлөлт олгох зорилготой юм. Энэхүү УСНББОУС-ыг мөрдөхийн өмнө, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-д шилжихэд зохих ёсоор бэлтгэсэн байвал зохино. Шилжилтийн нарийн төвөгтэй байдал ба зарцуулах хугацаа нь түүний нягтлан бодох бүртгэлийн өмнөх сууриас хамаардаг. Гурван жилийн чөлөөлөлтийн хугацааг нийт мөрдөлтийн үе шат гэж үзэхгүй.
- ДҮ46. УСНББОУСЗ-өөс гаргасан Судалгаа 14, *Нягтлан Бодох Бүртгэлийн Аккруэл Суурьт Шилжилт: Засгийн Газар болон Засгийн Газрын Байгууллагуудад Зориулсан Заавар Удирдамж*-д дурдсан, заавар удирдамж нь анх удаа мөрдөж буй байгууллага энэхүү УСНББОУС-ыг мөрдөхийн өмнө, өөрийн аккруэл суурьт УСНББОУС-д шилжилтийг төлөвлөхөд тусалцаа үзүүлж болох юм.
- ДҮ47. УСНББОУСЗ нь дараах хөрөнгүүдэд гурван жилийн чөлөөлөлтийн хугацаа олгох хэрэгтэй гэж үзсэн:
- (а) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө;
  - (б) Үндсэн хөрөнгө;
  - (в) Биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн;
  - (г) Биет бус хөрөнгө; ба
  - (д) Үйлчилгээний концессын хөрөнгө.
- ДҮ48. Энэхүү санал болгосон УСНББОУС-ын талаархи саналыг хүлээн авсны дараа, УСНББОУСЗ нь бараа материалын хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлтийн хугацаа бас олгохыг зөвшөөрсөн. Хэдийгээр бараа материал нь байгууллагын үйл ажиллагааны циклийн дотор хэрэгжүүлж, зарцуулж, борлуулж, ашиглаж болох эргэлтийн хөрөнгө боловч анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн хөрөнгүүдийг тодорхойлж, бараа материал, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгө гэдгээр зохих ёсоор ангилахад, ялангуяа газрын хувьд хугацаа шаардагдаж болох учраас УСНББОУСЗ нь ийм чөлөөлөлтийг зөвшөөрсөн. Мөн бараа материал нь тухайлбал, эмнэлгийн хангамжийн зүйлс гэх мэт тусгайлсан хөрөнгө эсвэл маш их тоо хэмжээтэй зүйлсээс бүрдэж болох учраас тэдгээрийн хувьд зохих ангилал хийхэд нэмэлт хугацаа шаардагдаж болох юм.

- ДҮ49. Биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлтийн хугацаа олгох хэрэгтэй эсэхийг харгалзан үзэхдээ, УСНББОУСЗ нь эдгээр хөрөнгө ба үйл ажиллагаанууд зарим улс орны хувьд нийтлэг бус байж болох боловч зарим улс оронд, тухайлбал, хөгжиж буй улс орнуудад чухал ач холбогдолтой байж болно гэдгийг онцлон тэмдэглэсэн. Эдгээрийн тэнцвэрийг хангаж, УСНББОУСЗ нь биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн чухал асуудал болдог тийм улс орнуудад туслахын тулд тэдгээр хөрөнгүүдийн хувьд гурван жилийн чөлөөлөлтийн хугацаа олгохыг зөвшөөрсөн.
- ДҮ50. Анх удаа мөрдөж буй байгууллага нь шалгуур хангасан хөрөнгүүдийн хувьд гарсан зээлийн өртгийг тайлагнахдаа бенчмарк хандлага эсвэл зөвшөөрөгдсөн сонголтот хандлагын аль нэгийг ашиглахыг УСНББОУС 5-аар зөвшөөрсөн байдаг. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зөвшөөрөгдсөн сонголтот хандлагыг ашиглах сонголт хийсэн бол шалгуур хангасан хөрөнгүүдэд зээлийн өртгийг капиталжуулах өдөр ба зарим хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй байх гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг уг анх удаа мөрдөж буй байгууллага ашиглах үе хооронд хугацааны зөрүү үүсэж болох юм. Энэхүү хугацааны зөрүүг харгалзан үзэх, түүнчлэн анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашиглах тохиолдолд уг хөрөнгийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө гарсан зээлийн өртгийн талаархи мэдээллийг олж авах практик боломжгүй байдлын улмаас УСНББОУСЗ нь аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө эхлэх капиталжуулалтын хугацаа бүхий шалгуур хангах хөрөнгүүдийн хувьд аливаа зээлийн өртгийг капиталжуулахыг тэрхүү анх удаа мөрдөж буй байгууллагаас шаардахгүй байхыг зөвшөөрсөн. Тухайн санал болгосон Саналын Төсөлд хариулт өгсөн хүмүүсээс хүлээн авсан санал зөвлөмжид үндэслэн УСНББОУСЗ нь ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөх (аль түрүүнд болох өдөр) хүртэл тухайн шилжилтийн хугацаанд гарсан аливаа зээлийн өртгийг мөн капиталжуулахгүй байхыг зөвшөөрсөн.
- ДҮ51. Санал болгосон УСНББОУС-ын талаархи саналыг хүлээн авсны дараа УСНББОУСЗ нь анги буюу ангилал ашиглахыг зохих УСНББОУС-аар зөвшөөрдөг тохиолдолд хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг анги бүрээр эсвэл ангилал бүрээр өөрчлөхийг анх удаа мөрдөж буй байгууллагад бас зөвшөөрсөн.

*Санхүүгийн бус хөрөнгийн хэмжилттэй холбоотой шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд*

- ДҮ52. Зарим байгууллага нь санхүүгийн бус хөрөнгийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн байж болно гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Иймээс УСНББОУСЗ нь анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн, бүх санхүүгийн бус хөрөнгийн хэмжилтийн хувьд чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацаа олгохыг зөвшөөрсөн. Энэхүү

шилжилтийн хугацаанд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-д заасан зарчмуудыг мөрдөхөд зориулсан найдвартай загварыг боловсруулах боломжтой болох юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь шилжилтийн хугацааны туршид эдгээр хөрөнгийн хэмжилтийн талаархи өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх шаардлагагүй юм.

*Өр төлбөрийн хэмжилттэй холбоотой шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд*

Хөрөнгийн стандартууд ба бусад УСНББОУС-ын хоорондох уялдаа холбоо

ДҮ53. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгүүдийн хүлээн зөвшөөрөлттэй холбоотой шилжилтийн үеийн нэг буюу хэд хэдэн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд энэхүү үйл явцын нэг хэсэг болгон тус байгууллага нь ямар хөрөнгийг тайлагнах эсэх, түүнчлэн тэдгээрийн хэмжилтийг тодорхойлохдоо эрхийн бүртгэл, гэрээ болон бусад адилтгах хэлцлүүдийг, үүн дотроо түрээсийн гэрээг шинжилж үзнэ. Үүний үр дүнд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгүүдийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөх (аль түрүүнд болох өдөр) хүртэл санхүүгийн түрээсийн хөрөнгөтэй холбоотой санхүүгийн түрээсийн өр төлбөрийг тайлагнахгүй байх байр суурьтай болж болох юм.

ДҮ54. Үүнтэй адилаар, анх удаа мөрдөж буй байгууллага нь үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд УСНББОУС 32-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийг ашиглах сонголт хийсэн тохиолдолд ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгүүдийг УСНББОУС 32-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл тус байгууллага нь холбогдох өр төлбөрийг санхүүгийн өр төлбөрийн загвар эсвэл концесс эзэмшигчид эрх олгох загварын аль нэгээр тайлагнахгүй байх байр суурьтай болж болох юм.

ДҮ55. Холбогдох хөрөнгүүдэд олгосон чөлөөлөлтийн хугацаа дуусах ба/буюу тэдгээр хөрөнгүүдийг хүлээн зөвшөөрч, хэмжих хүртэл санхүүгийн түрээсийн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт болон үйлчилгээний концессын хөрөнгөтэй холбоотой өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийг бас хойшлуулах хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 зөвшөөрсөн.

Үндсэн хөрөнгийн анхны өртөгт тусгасан нөөцийн хүлээн зөвшөөрөлт

ДҮ56. УСНББОУС 19-д заасан нөөцийн хувьд шилжилтийн үеийн чөлөөлөх хугацаа олгох хэрэггүй бөгөөд анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр өөрийн бүх өр төлбөрийг тайлагнах хэрэгтэй гэж УСНББОУС3 дүгнэсэн. Гэвч үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн ийм хойшлуулалт нь тэдгээр хөрөнгийн өртөгт тусгах зарим нөөцийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтэд нөлөөлнө гэдгийг УСНББОУС3 мэдэгдсэн.

- ДҮ57. УСНББОУС 17 нь үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын, түүнчлэн уг зүйлийг олж бэлтгэх үед эсвэл тухайн хугацааны туршид бараа материал үйлдвэрлэхээс өөр бусад зорилгоор түүнийг тодорхой хугацаанд ашигласны үр дүнд байгууллагын хүлээх үүргийн анхны тооцоолсон дүнг тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн өртгийн нэг хэсэг байдлаар тусган оруулахыг байгууллагаас шаарддаг. УСНББОУС 17-гийн дагуу бүртгэж тайлагнасан өртөг зардлуудын холбогдох өр төлбөрийг УСНББОУС 19-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжихийг УСНББОУС 17-гоор шаардсан байдаг.
- ДҮ58. Харгалзах үндсэн хөрөнгийн зүйлийг УСНББОУС 17-гийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих хүртэл тухайн үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын анхны тооцоолсон дүнгийн хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжих боломжгүй гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн. Иймээс энэхүү цаг хугацааны зөрүүг харгалзан үзэхийн тулд нөөцийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд мөн шилжилтийн үеийн чөлөөлөлтийн хугацаа олгосон.

УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж

- ДҮ59. УСНББОУС 39-д заасан, тусгай өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилт нь шинэ систем шаардах буюу одоо байгаа системийг сайжруулахыг шаардаж болох учраас улсын секторын олон байгууллагын хувьд асуудал үүсгэнэ гэдгийг УСНББОУС3 мэдэгдсэн. Иймээс УСНББОУС3 нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр ба ажилтны урт хугацааны бусад тэтгэмжтэй холбоотой хөрөнгө болон өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацааг уг анх удаа мөрдөж буй байгууллагад олгох хэрэгтэй гэдгийг зөвшөөрсөн. Санхүүгийн байдлын тайланг гажуудуулахаас сэргийлэхийн тулд УСНББОУС3 нь аливаа хөтөлбөрийн хөрөнгийг түүний өр төлбөртэй ижил хугацаанд хүлээн зөвшөөрч, хэмжих хэрэгтэй гэдгийг мөн хүлээн зөвшөөрсөн. Ажилтны бусад бүх тэтгэмжийг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр хүлээн зөвшөөрч, хэмжих хэрэгтэй.

ДҮ60. [Хассан]

*Мөнгөн зүйлийн хөрөнгө ба/буюу өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилттэй холбоотой шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд*

*УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*

- ДҮ61. УСНББОУС 29-д заасан, одоо байгаа шилжилтийн нөхцлүүд нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд уг анх удаа мөрдөж буй байгууллагад ямар нэг чөлөөлөлт олгодоггүй. Улсын секторын олон байгууллагууд нь өөрсдийн санхүүгийн хэрэглүүрийг тогтоох ба зохих ёсоор ангилахад тодорхой хугацаа шаардлагатай учраас УСНББОУС3 нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд уг

анх удаа мөрдөж буй байгууллагад шилжилтийн үеийн чөлөөлөх хугацаа олгох хэрэгтэй гэдгийг зөвшөөрсөн. Бусад зүйлсийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд олгосон чөлөөлөлтийн хугацаатай уялдуулан гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх хугацааг олгосон.

ДҮ62. Гэвч УСНББОУСЗ нь санхүүгийн хэрэглүүрийг өмнө нь хүлээн зөвшөөрч байсан ба хүлээн зөвшөөрдөггүй байсан байгууллагуудыг өөр хооронд нь ялган үзэх хэрэгтэй гэж мэдэгдсэн. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, мөнгө, авлага, өглөг гэх мэт олон, суурь санхүүгийн хэрэглүүрийг улсын секторын байгууллагууд угаасаа хүлээн зөвшөөрсөн байдаг. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй байсан санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд гурван жилийн чөлөөлөлтийн хугацааг олгох юм.

ДҮ63. УСНББОУСЗ нь мөнгөн зүйлсийн хөрөнгө, ер төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтэнд мөрддөгтэй ижил зарчмыг мөнгөн зүйлсийн бус хөрөнгийн хувьд мөрдөх хэрэгтэй гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу санхүүгийн хэрэглүүрийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд УСНББОУСЗ нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн дараах, санхүүгийн хэрэглүүрийн хэмжилт, ангиллын хувьд гурван жилийн чөлөөлөх хугацааг олгох хэрэгтэй гэдгийг зөвшөөрсөн. Энэхүү шилжилтийн хугацаанд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 29-д заасан зарчмуудыг мөрдөхөд зориулсан найдвартай загварыг боловсруулах боломжтой болох юм. Мөн санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтийн хувьд УСНББОУС 29-д заасан, шаардлагуудаас өөр нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тэрхүү шилжилтийн хугацаанд мөрдөх боломжийг тус байгууллагад олгох юм.

*Арилжааны бус орлогын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилттэй холбоотой шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд*

*УСНББОУС 23, Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*

ДҮ64. УСНББОУС 23-д заасан, одоо байгаа шилжилтийн нөхцлүүд нь уг анх удаа мөрдөж буй байгууллага татварын орлогын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн хувьд өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг таван жилийн хугацаанд өөрчлөхгүй байхыг зөвшөөрдөг. Мөн УСНББОУС 23 нь уг анх удаа мөрдөж буй байгууллага татварын орлогоос бусад, арилжааны бус ажил гүйлгээний орлогын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн хувьд өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг таван жилийн хугацаанд өөрчлөхгүй байхыг зөвшөөрдөг. Түүнчлэн, УСНББОУС 23 нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг УСНББОУС 23-тай илүү сайн нийцэх зөвхөн тийм үед хийх хэрэгтэй гэж шаарддаг.

ДҮ65. Шинэ систем шаардах ба/буюу одоо байгаа системийг сайжруулахыг шаардаж болох учраас УСНББОУС 23-ыг хэрэгжүүлэхэд улсын секторын олон байгууллагад хүндрэлтэй асуудал үүснэ гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Ийм практикын хүндрэлтэй асуудлуудын улмаас УСНББОУСЗ нь

шилжилтийн үеийн чөлөөлөх хугацааг олгох хэрэгтэй гэдгийг зөвшөөрсөн. Гэвч анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурийг мөрдөхийн өмнө аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлд шилжихэд туслалцаа үзүүлэх загваруудыг боловсруулах хэрэгтэй гэж УСНББОУСЗ мэдэгдсэн. Бусад УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтөд олгосон гурван жилийн чөлөөлөх хугацаатай уялдуулах ба УСНББОУС 23-д заасан, бусад арилжааны бус орлогод олгосон гурван жилийн чөлөөлөх хугацаатай уялдуулах үүднээс арилжааны бус ажил гүйлгээний орлогыг хүлээн зөвшөөрөх, хэмжих найдвартай загваруудыг боловсруулахад уг анх удаа мөрдөж буй байгууллагад гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх хугацаа олгох хэрэгтэй гэж үзсэн. Гурван жилийн шилжилтийн хугацаа нь удирдан зохицуулах илүү боломжтой бөгөөд аккруэл суурьт УСНББОУС-д нийцсэн гэж тус байгууллага мэдэгдэх боломжгүй байх хугацааг богиносгоно гэдгийг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын хүлээн зөвшөөрөлтийн хувьд УСНББОУС 23-ын заалтуудтай үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тэрхүү шилжилтийн хугацаанд мөрдөж болох юм.

*Анх удаа мөрдөж буй байгууллага нь шилжилтийн үеийн гурван жилийн чөлөөлөх хугацаа олгодог нөхцлүүдийн дагуу талыг ашиглах үед толилуулгын болон тодруулгын шаардлагуудаас чөлөөлөх*

ДҮ66. Хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд олгосон гурван жилийн чөлөөлөх нөхцөл нь мэдээлэл бэлэн боломжтой байхгүйн улмаас зохих УСНББОУС-д заасан, тэдгээрт хамаарах толилуулгын болон тодруулгын шаардлагуудыг мөрдөх албагүй гэсэн утгыг бас илэрхийлнэ гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгө, өр төлбөрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл тухайн мэдээллийг бүрдүүлэх шаардлагагүй гэдгийг УСНББОУСЗ зөвшөөрсөн.

ДҮ67. Үүнтэй ижил шалтгаанаар, УСНББОУСЗ нь УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*, УСНББОУС 18, *Сегментийн Тайлагнал*-д заасан, аливаа холбогдох тодруулгын шаардлагуудыг биелүүлэхийг уг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаардах хэрэггүй гэдгийг зөвшөөрсөн.

*УСНББОУС 5, Зээлийн Өртөг*

ДҮ68. Анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу зээлийн өртгийг хүлээн зөвшөөрдөггүй байсан бол санхүүгийн тайлангаа буцаах горимоор залруулахыг УСНББОУС 5-ын одоо байгаа шилжилтийн нөхцлүүдээр дэмждэг. УСНББОУС-ыг угаасаа мөрддөг байгууллагуудад олгосноос илүү чөлөөлтийг УСНББОУСЗ нь анх удаа мөрдөж буй байгууллагад олгохыг, ялангуяа уг анх удаа мөрдөж буй байгууллага нь шалгуур хангах хөрөнгийн худалдан авалт, барьж байгуулалт, үйлдвэрлэлд шууд хамаарах зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг байдлаар капиталжуулах, зөвшөөрөгдсөн сонголтот



хандлагыг хэрэглэхээр сонгосон тохиолдолд түүнд илүү чөлөөлөлт олгохыг хүсэхгүй байгаа гэдгээ мэдэгдсэн.

ДҮ69. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь бенчмарк хандлагыг мөрддөг эсвэл нягтлан бодох бүртгэлийн бодлогоо уг хандлага болгон өөрчилсөн зөвхөн тийм тохиолдолд УСНББОУС 5-ын шаардлагуудыг буцаах горимоор мөрдөхийг дэмжинэ гэдгээ УСНББОУСЗ мэдэгдсэн. Мэдээллийг буцаан олж авахад өртөг зардал ихтэй бөгөөд ийм мэдээллийг олж авахад нилээд хүчин чармайлт шаардаж болох учраас ийм чөлөөлөлт олгох шаардлагатай гэж үзсэн.

ДҮ70. Гэвч анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх сууриас хамааран зарим мэдээлэл нь түүнд бэлэн боломжтой байж болно гэдгийг УСНББОУСЗ дурдсан. Иймээс бенчмарк хандлагыг мөрддөг эсвэл нягтлан бодох бүртгэлийн бодлогоо уг хандлага болгон өөрчилсөн анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 5-д заасан зарчмуудыг гүйцээх горимоор мөрддөг боловч УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө байх өдрийг УСНББОУС 5-ыг мөрдөхдөө сонгож болно гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

ДҮ71. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зөвшөөрөгдсөн сонголтот хандлага ашиглахыг УСНББОУСЗ нь дэмжихийг хүсээгүй. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн хугацаанд хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байх чөлөөлөлтийн нөхцлийн давуу талыг ашигладаггүй тохиолдолд хэрэв уг анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг зөвшөөрөгдсөн сонголтот хандлага болгон өөрчилсөн бол капиталжуулалтын эхлэлийн өдөр нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө байх тийм шалгуур хангах хөрөнгүүдийн хувьд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө ба хойш гарсан аливаа зээлийн өртгийг буцаах горимоор хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг зөвшөөрсөн.

*УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан, УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан, УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*

ДҮ72. УСНББОУСЗ нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхгүй байхыг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрөх тийм шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл олгох хэрэгтэй эсэхийг харгалзан үзсэн. Ийм чөлөөлөлт олгох нь тайлагнагч байгууллагын ойлголт ухагдахуунтай зөрчилдөх бөгөөд үнэн зөв толилуулгад хүргэхгүй гэсэн шүүмжлэл энэхүү саналыг авч хэлэлцэх явцад гарч байсан.

ДҮ73. Иймээс УСНББОУСЗ нь нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулахгүй байх тийм чөлөөлөлтийг олгохгүй, харин үүний оронд анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэх шаардлагаас гурван жилийн хугацаанд чөлөөлөх нь зүйтэй гэж үзсэн.

ДҮ74. УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр зарим үлдэгдэл, ажил гүйлгээний орлого, зардал нь мэдэгдэж байж болох учраас анх удаа мөрдөж буй байгууллага нь зөвхөн тэдгээр мэдэгдэж буй үлдэгдэл, ажил гүйлгээний орлого, зардлыг устгаж цэвэрлэхийг дэмждэг.

ДҮ75. Анх удаа мөрдөж буй байгууллага нь нэг буюу хэд хэдэн хамтын хяналт бүхий байгууллагатай тохиолдолд УСНББОУС 8-ын, харин нэг буюу хэд хэдэн хараат байгууллагатай тохиолдолд УСНББОУС 7-гийн шаардлагуудаас мөн адил чөлөөлөхийг УСНББОУСЗ нь дээр дурдсантай ижил шалтгаанаар зөвшөөрсөн.

*Бусад байгууллагууд дахь хувь оролцооны анхны хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох*

ДҮ76. Саналын Төслийн талаархи саналуудыг хүлээн авсны дараа УСНББОУСЗ нь бусад байгууллагууд дахь түүний хувь оролцооны анхны хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд уг анх удаа мөрдөж буй байгууллагад чөлөөлөлтийн хугацаа олгох хэрэгтэй гэдгийг зөвшөөрсөн. Ийм чөлөөлөлт нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр шаардлагатай мэдээллийг цуглуулж бүрдүүлээгүй тэдгээр анх удаа мөрдөж буй байгууллагуудад өөрсдийн бусад байгууллага дахь хувь оролцоогоо зохих ёсоор ангилж, хэмжих илүү их цаг хугацаа олгох юм. Ингэж олгосон чөлөөлөх нөхцөл нь санхүүгийн хэрэглүүрийн хувьд олгосон чөлөөлөлттэй нийцсэн байна.

*Бусад байгууллагууд дахь хувь оролцооны анхны хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилт, түүнчлэн байгууллага хоорондын үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэхгүй байхад зориулан гурван жилийн чөлөөлөлтийн хугацаа олгосон үед нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулах*

ДҮ77. Анх удаа мөрдөж буй байгууллага нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох бүх буюу зарим үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэхгүй байх сонголт хийсэн тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхээс чөлөөлөх хэрэгтэй гэсэн үзэл баримтлалыг уг Саналын Төсөлд хариулт өгсөн зарим хүмүүс илэрхийлсэн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь бусад байгууллагууд дахь өөрийн хувь оролцооны анхны хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг ба/буюу байгууллага хоорондын бүх буюу зарим үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэхгүй байх сонголт хийсэн үед толилуулсан санхүүгийн тайланг (а) ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу (б) байгууллага хоорондын үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэх ба/буюу (в) бусад байгууллагууд дахь өөрийн хувь оролцоог зохих ёсоор хүлээн зөвшөөрч, хэмжих хүртэл нэгтгэсэн санхүүгийн тайлан байдлаар толилуулж болохгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Тухайн санхүүгийн тайланг яагаад нэгтгэсэн санхүүгийн тайлан гэж толилуулаагүй болохыг хэрэглэгчдэд тайлбарлахын тулд тодруулгын шаардлагуудыг нэмж оруулах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ зөвшөөрсөн.

ДҮ78. Анх удаа мөрдөж буй байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ УСНББОУС 35-аар шаардсаны дагуу байгууллага хоорондын үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлээгүй тохиолдолд энэ нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллага хоорондын үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлын зөвхөн нэгтгэн нийлүүлсэн дүн болох учраас ийм тодруулсан тайлбар хийх шаардлагатай гэж УСНББОУСЗ үзсэн. Ийм тайлан нь хариуцлага ба шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолгүй байдаг.

ДҮ79. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зохих УСНББОУС-аар шаардсаны дагуу бусад байгууллагууд дахь өөрийн хувь оролцоог хүлээн зөвшөөрч, хэмжээгүй бол дээрхтэй адилаар, хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтын дансны үнийг УСНББОУС 35-аар шаардсаны дагуу устгаж цэвэрлэх боломжгүй байж болох юм.

#### *УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл*

ДҮ79А. УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь улсын секторын нэгдэлтэй холбоотой бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрөх шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл олгох эсэхийг авч үзсэн. УСНББОУС 40-ийг гүйцээх горимоор мөрддөг, иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь уг Стандартыг мөрдөхөөс өмнө гарч тохиолдсон улсын секторын нэгдлийн хувьд өөрийн нягтлан бодох бүртгэлд залруулга хийх шаардлагагүй гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Гэвч анх удаа мөрдөж буй байгууллагын гурван жилийн шилжилтийн хугацаанд улсын секторын нэгдэл хийгдэж болох юм. Ижил төсөөтэй бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, хэмжихийг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаардахгүй, харин улсын секторын нэгдэлтэй холбоотой бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, хэмжихийг түүнээс зөвхөн шаардах нь тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллийг бүрдүүлэхгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ79Б. Иймээс, УСНББОУСЗ нь улсын секторын нэгдэлтэй холбоотой бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрөх шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийг энэхүү Стандартын нэг хэсэг байдлаар олгохыг зөвшөөрсөн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь улсын секторын нэгдэлтэй холбоотой бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, хэмждэггүй тохиолдолд гүүдвилийг хүлээн зөвшөөрөх хэрэггүй гэдгийг УСНББОУСЗ нь бас хүлээн зөвшөөрсөн.

**Үнэн зөв толилуулга ба аккруэл суурт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй чөлөөлөх нөхцлүүд**

*Төсөөлөн тооцсон өртөг*

Хөрөнгө ба/буюу өр төлбөрийн төсөөлөн тооцсон өртөг

ДҮ80. УСНББОУС-ын дагуу хийгдэх зарим хэмжилт нь өнгөрсөн хугацааны өртөг зардлын хуримтлуулалт болон ажил гүйлгээний бусад мэдээнд үндэслэдэг. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь уг шаардлагатай мэдээллийг өмнөх тайлант үед цуглуулж бэлтгээгүй бол түүнийг буцаан цуглуулах буюу тооцоолоход ихээхэн зардалтай ба/буюу практик боломжгүй байж болох юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 16-д заасан, өртгийн загварыг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр үндсэн хөрөнгө, санхүүгийн хэрэглүүр, үйлчилгээний концессын хөрөнгөнд ашиглах сонголт хийсэн тохиолдолд илүүдэл зардал гаргахаас зайлсхийхийн тулд УСНББОУС3 нь бараа материал, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн анхны өртгийн орлуулагч болгон бодит үнэ цэнийг ашиглахыг уг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрдөг. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байх гурван жилийн чөлөөлөлтийн хугацаа олгосон нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд уг бодит үнэ цэнэ нь шилжилтийн хугацаанд тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн өдрөөрх төсөөлөн тооцсон өртөг болно.

ДҮ81. Бодит үнэ цэнийг ашиглах нь зэрэгцүүлэгдэх байдлыг алдагдуулна гэж шүүмжилж болох боловч өртөг нь уг худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэтэй ерөнхийдөө тэнцүү байдаг гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Иймээс бодит үнэ цэнийг хөрөнгийн төсөөлөн тооцсон өртөг байдлаар ашиглах нь анх удаа мөрдөж буй байгууллага УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр ижил үнэ цэнэ буюу үлдсэн ижил үйлчилгээний чадавхи бүхий хөрөнгийг олж эзэмшсэнтэй адил тийм өртгийн мэдээг тайлагнана гэсэн үг юм. Хэрэв зэрэгцүүлэгдэх байдал ямар нэг хэмжээгээр алдагдвал энэ нь зарим хөрөнгийн хувьд тухайн өдөр төсөөлөн тооцсон өртөг болгон бодит үнэ цэнийг ашигласнаас биш, харин өөр өөр хугацаанд гарсан өртөг зардлыг нэгтгэн нийлүүлснээс шалтгаалсан байдаг. УСНББОУС3-ийн үзэл бодлоор бол төсөөлөн тооцсон өртгийг ашиглах нь өртөг зардлын хэмнэлттэй байдлаар УСНББОУС-ыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг.

ДҮ82. Хэрэв байгууллага нь УСНББОУС 17-д заасан, дахин үнэлгээний загварын дагуу ямар нэг хөрөнгийг дахин үнэлсэн бол тухайн ангид хамаарах бүх хөрөнгийг дахин үнэлэх ёстой. Ийм хязгаарлалт нь дахин үнэлснээр тодорхой үр дүнд хүргэх зөвхөн тийм хөрөнгүүдийг сонгож, дахин үнэлэхээс сэргийлдэг. УСНББОУС3 нь төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлоход үүнтэй адил хязгаарлалт оруулах хэрэгтэй эсэхийг авч үзсэн. УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* ба УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* нь хөрөнгийн үнэ цэнэ буурсан ямар нэг шинж тэмдэг байгаа бол үнэ цэнийн бууралтын сорил хийхийг шаарддаг. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь

өртгөөсөө бодит үнэ цэнэ нь өндөр байх магадлалтай хөрөнгүүдийн хувьд төсөөлөн тооцсон өртөг болгон бодит үнэ цэнийг ашигласан бол бусад хөрөнгүүдийн нөхөгдөх дүн буюу нөхөгдөх үйлчилгээний дүн нь өөрсдийн дансны үнээс бага болтол буурсан байж болох шинж тэмдгийг уг байгууллага харгалзан үзэхгүй орхигдуулж болохгүй юм.

ДҮ83. УСНББОУС-ыг анх мөрдсөн өдөр, төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлохыг уг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрдөг, эсвэл анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгийг шилжилтийн үеийн гурван жилийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тийм нөхцөл байдлуудыг УСНББОУСЗ нь мөн харгалзан үзсэн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгийг шилжилтийн үеийн гурван жилийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр эсвэл УСНББОУС-ыг мөрдсөн өдөр өртгийн мэдээлэл бэлэн боломжтой байгаа эсэхээс үл хамааран бүх нөхцөл байдалд төсөөлөн тооцсон өртөг ашиглахыг зөвшөөрөх хэрэгтэй, эсвэл хөрөнгийн өртгийн мэдээлэл бэлэн боломжтой байх тийм нөхцөл байдлуудаар төсөөлөн тооцсон өртөг ашиглахыг хязгаарлах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн.

ДҮ84. Хөрөнгүүдийг сонгож үнэлэхээс зайлсхийхийн тулд УСНББОУСЗ нь тухайн хөрөнгийн түүхэн өртгийн талаархи найдвартай мэдээлэл бэлэн боломжтой байхгүй зөвхөн тийм нөхцөл байдлуудаар төсөөлөн тооцсон өртөг ашиглалтыг хязгаарлах хэрэгтэй гэж дүгнэсэн.

Хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын төсөөлөн тооцсон өртөг

ДҮ85. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтыг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр өөрийн тусдаа санхүүгийн тайландаа УСНББОУС 6-гийн дагуу тодорхойлсон өртгөөр эсвэл төсөөлөн тооцсон өртгөөр хэмжих сонголт хийж болно гэдгийг УСНББОУСЗ бас хүлээн зөвшөөрсөн. Төсөөлөн тооцсон өртгийг УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн дагуу бодит үнэ цэнэ байдлаар тодорхойлдог.

Биет бус хөрөнгийн төсөөлөн тооцсон өртөг

ДҮ86. Биет бус хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртөг тодорхойлохыг уг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг тогтоохдоо УСНББОУСЗ нь УСНББОУС 31-д заасан, одоо байгаа шилжилтийн нөхцлүүдийг харгалзан үзсэн. Хэрэв дахин үнэлгээ нь бодит үнэ цэнэтэй, эсвэл тухайлбал, үнийн ерөнхий болон тусгай индексийн өөрчлөлтийг тусгахын тулд тохируулга хийсэн өртөг буюу хорогдуулга тооцсон өртөгтэй зэрэгцүүлэгдэх боломжтой байвал анх удаа мөрдөж буй байгууллага нь шилжилтийн өдөр болон түүнээс өмнө хийгдсэн, биет бус хөрөнгийн өмнөх

дахин үнэлгээг тэрхүү дахин үнэлгээний өдрөөрх төсөөлөн тооцсон өртөг болгон ашиглахыг УСНББОУС 31-ээр зөвшөөрсөн байдаг. Гэвч УСНББОУС 31-д заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуур (үүн дотроо, анхны өртгийн найдвартай хэмжилт) болон дахин үнэлгээний шалгуур (үүн дотроо, идэвхитэй зах зээлийн оршин байдал) хангагдсан зөвхөн тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлохыг УСНББОУС 31-ээр зөвшөөрдөг.

- ДҮ87. Улсын секторын байгууллагууд нь УСНББОУС-ыг анх мөрдөх үед хоёр дахь шалгуурыг өөрөөр хэлбэл, идэвхитэй зах зээл оршин байх шалгуурыг хангах магадлалтай эсэхийг УСНББОУС3 нь харгалзан үзсэн. Биет бус хөрөнгийн хувьд улсын секторт идэвхитэй зах зээл оршин байх нь нийтлэг бус байж болох бөгөөд үүний улмаас төсөөлөн тооцсон өртгийн хандлага ашиглалт нь үлэмж хязгаарлагдах магадлалтай гэдгийг УСНББОУС3 мэдэгдсэн. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь дотоодоо хөгжүүлсэн мэдээллийн технологийн систем гэх мэт зарим биет бус хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлох боломжгүй байж болох юм.
- ДҮ88. Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг өмнө нь мөрдөж байсан, уг анх удаа мөрдөж буй зарим байгууллагууд нь өөрсдийн биет бус хөрөнгийн анхны өртгийг тодорхойлоход төвөгтэй байж болох тул анхны өртгийн найдвартай хэмжилт тэдэнд шаардлагатай эсэхийг УСНББОУС3 нь авч үзсэн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг өмнө нь мөрдөж байсан боловч арилжааны бус ажил гүйлгээгээр биет бус хөрөнгүүдийг олж эзэмшсэн тохиолдолд анхны өртгийг найдвартай хэмжих боломжгүй байж болно гэж бас маргадаг.
- ДҮ89. Эдгээр анхаарах зүйлсэд үндэслэн, УСНББОУС3 нь анхны өртгийн найдвартай хэмжилтийг УСНББОУС-ыг анх мөрдөх үед төсөөлөн тооцсон өртгийг ашиглах шалгуураас хасах хэрэгтэй гэж дүгнэсэн.
- ДҮ90. Иймээс төсөөлөн тооцсон өртөг нь (а) УСНББОУС 31-д заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуур (найдвартай хэмжилтийн шалгуур хамаарахгүй), (б) УСНББОУС 31-д заасан, дахин үнэлгээний шалгуур (үүн дотроо, идэвхитэй зах зээлийн оршин байдал)-ыг хангах тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь биет бус хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртөг тодорхойлохыг зөвшөөрнө гэдгийг УСНББОУС3 мэдэгдсэн.
- ДҮ91. Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртөг тодорхойлохыг уг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг тогтоохдоо, УСНББОУС3 нь ийм мэдээллийг олж авах үедээ удирдлага үр дүнг буцаан хэрэглэх боломжгүй байх тул үндэслэлтэй ба дэмжин нотлогдох таамаглалуудаар тэрхүү хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн магадлалыг буцаан үнэлэхэд төвөгтэй гэж дүгнэсэн. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр найдвартай мэдээлэл байхгүйн улмаас дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлохгүй байж болно гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Төсөөлөн тооцсон өртөг тодорхойлох бодит үнэ цэнийн хэмжилтийн хувилбар сууриуд

ДҮ92. Анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн зарим дахин үнэлгээ нь анхны өртөгтэй харьцуулахад хэрэглэгчдэд илүү ач холбогдолтой байж болно гэж УСНББОУСЗ үзсэн. Хэрэв өмнөх дахин үнэлгээ нь УСНББОУС-тай угаасаа нийцэж байвал өртгийн талаархи цаг хугацаа зарцуулсан, өртөг зардал ихтэй тооцооллыг шаардах нь ул үндэслэлгүй юм гэж дүгнэсэн. Иймээс энэхүү УСНББОУС нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс өмнө, өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу үндсэн хөрөнгийн хувьд тодорхойлсон дахин үнэлгээг төсөөлөн тооцсон өртөг болгон ашиглахыг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрдөг. Хэрэв дахин үнэлгээний өдрөөрх уг дахин үнэлсэн дүн нь дараах дүнгүүдтэй зэрэгцүүлэгдэх боломжтой байвал түүнийг ашиглаж болно:

(а) Бодит үнэ цэнэ; эсвэл

(б) Хэрэв тохиромжтой бол тухайлбал, үнийн ерөнхий болон тусгай индексийн өөрчлөлтийг тусгахын тулд УСНББОУС-ын дагуу тохируулга хийсэн өртөг буюу хорогдуулга тооцсон өртөг.

ДҮ93. “Бодит үнэ цэнэ”-ийг тодорхойлохдоо, хэрэв заавар удирдамжийг тусгасан бол зохих УСНББОУС бүрд заасан, заавар удирдамжийг харгалзан үзнэ. Бодит үнэ цэнийг ихэвчлэн зах зээлд суурилсан нотолгооны дагуу үнэлгээгээр тодорхойлдог гэж УСНББОУС 17-д заасан байдаг. Үндсэн хөрөнгийн зүйлсийг хэмжих зах зээлд суурилсан нотолгоо байхгүй тохиолдолд байгууллага нь орлуулалтын өртөг, дахин үйлдвэрлэн бий болгох өртөг, үйлчилгээний нэгжийн хандлагыг ашигласнаар бодит үнэ цэнийг тооцоолж болно гэж УСНББОУС 17-д бас заасан.

ДҮ94. УСНББОУС 16 дахь бодит үнэ цэнийн заавар удирдамжид зөвхөн зах зээлд суурилсан үнэ цэнийг авч үзсэн ба бодит үнэ цэнийг тодорхойлох талаар УСНББОУС 12-д цөөн заавар удирдамжийг тусгасан гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь бүх хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө ба бүх бараа материалын хувьд зах зээлд суурилсан бодит үнэ цэнийг тодорхойлоход төвөгтэй гэж үзэж болох учраас бараа материал болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд төсөөлөн тооцоолсон өртгийг тодорхойлохдоо хэмжилтийн бусад хувилбаруудыг харгалзан үзэх шаардлагатай байж болно гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ95. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван жилийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн өдөр, эсвэл УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хэрэв бодит үнэ цэнийн зах зээлд суурилсан найдвартай нотолгоо байхгүй бол тус байгууллага нь төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлохдоо хэмжилтийн дараах хувилбаруудыг харгалзан үзэж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн:

- (а) Бараа материалын хувьд, одоогийн орлуулалтын өртөг; ба
- (б) Тусгай шинж чанартай хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд, элэгдэл тооцсон орлуулалтын өртөг.

Анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн хугацаа олгодог чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг үед төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлох

ДҮ96. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог, шилжилтийн үеийн нэг буюу хэд хэдэн нөхцүүдийг мөрдөх сонголт хийсэн тохиолдолд тус байгууллага нь тухайн хөрөнгийн үнэ цэнийг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр буцаах горимоор залруулах боломжгүй байж болно гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Хөрөнгийн үнэ цэнийг буцаах горимоор залруулах нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр оршин байсан, тухайн хөрөнгийн үнэ болон зах зээлийн бусад хүчин зүйлсийг, үүн дотроо уг хөрөнгийн үнэ цэнэ буурсан аливаа шинж тэмдэг байгаа эсэхийг харгалзан үзэхийг шаарддаг.

ДҮ97. Энэ нь өртөг зардлын хувьд үр ашиггүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тэрхүү гурван жилийн шилжилтийн хугацаанд дахь дурын өдрөөр уг хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлж болно гэдгийг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн аливаа тохируулгыг тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн тайлант жилийн хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрдөг.

#### *УСНББОУС 18, Сегментийн Тайлагнал*

ДҮ98. Сегментийн мэдээллийн толилуулгын хувьд анх удаа мөрдөж буй байгууллагад чөлөөлөлтийн хугацаа олгох хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Сегментийн мэдээллийг толилуулахад ашигласан мэдээллийг тухайн санхүүгийн тайланд одоо байгаа мэдээлэлд үндэслэн бүрдүүлэх шаардлагатай тул сегментийн мэдээллийн толилуулга нь ач холбогдолтой байж болох эсэхээс үл хамааран уг анх удаа мөрдөж буй байгууллагад чөлөөлтийн хугацаа олгох хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ зөвшөөрсөн.

ДҮ99. Хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд шилжилтийн үеийн гурван жилийн чөлөөлөх хугацаа олгохыг УСНББОУСЗ зөвшөөрсөн тул ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дууссан буюу холбогдох зүйлсийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн (аль түрүүнд болох өдөр) зөвхөн тэр үед сегментийн мэдээллийг толилуулахад шаардлагатай мэдээлэл нь бэлэн боломжтой болдог. Сегментийн ач холбогдолтой тайланг толилуулах хамааралтай ба найдвартай мэдээлэл нь шилжилтийн хугацаанд бэлэн боломжтой байхгүй байж болох бөгөөд сегментийн тайлангийн толилуулга нь аккруэл суурьт УСНББОУС-д шилжих явцад хэрэглэгчдэд нэн чухал биш байж болох



учраас сегментийн мэдээллийн толилуулгын хувьд мөн гурван жилийн чөлөөлөлтийн хугацааг олгох хэрэгтэй гэж үзсэн.

ДҮ100. Санхүүгийн тайланд толилуулсан элементүүдийн хувьд шаардах мэдээлэлтэй харьцуулахад сегментийн мэдээлэл нь нэмэлт шинжтэй тул ийм чөлөөлөлт олгох нь тохиромжтой гэж УСНББОУСЗ мөн дүгнэсэн.

*УСНББОУС 20 Холбоотой Талуудын Тодруулга*

ДҮ101. Өөрийн холбоотой талуудын харилцаа ба холбоотой талуудын ажил гүйлгээний талаархи мэдээллийг бүрдүүлэх цаг хугацааг уг анх удаа мөрдөж буй байгууллагад олгохын тулд УСНББОУСЗ нь УСНББОУС 6-гаас УСНББОУС 8-д заасан, байгууллагуудын хоорондох үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэхтэй ижил төсөөтэй байдлаар тэдгээр холбоотой талуудын харилцаа, холбоотой талуудын ажил гүйлгээ, эрх бүхий албан тушаалтны талаархи мэдээллийн тодруулгыг авч үзэх хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

ДҮ102. Иймээс энэхүү УСНББОУС нь холбоотой талуудын харилцаа, холбоотой талуудын ажил гүйлгээ, эрх бүхий албан тушаалтны талаархи мэдээллийн тодруулгын хувьд шилжилтийн үеийн гурван жилийн чөлөөлөх хугацаа олгосон.

*УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт ба УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*

ДҮ103. Анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэ цэнийн бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлт ба буцаалтын хувьд УСНББОУС 21, УСНББОУС 26-д заасан, шаардлагуудаас өөр нягтлан бодох бүртгэлийн бодлого мөрддөг эсвэл үнэ цэнийн бууралтыг огт харгалзан үздэггүй байж болох юм гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын еерчлөлтийг буцаах горимоор мөрдсөний үр дүн болох залруулга нь үр дүнг буцаан хэрэглэхийг шаарддаг тул УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр түүний дүнг тодорхойлоход төвөгтэй байж болох юм.

ДҮ104. Иймээс УСНББОУСЗ нь УСНББОУС 21 ба УСНББОУС 26-г гүйцээх горимоор мөрдөх хэрэгтэй гэдгийг зөвшөөрсөн боловч эхлэлийн санхүүгийн байдлын тайлан дахь мөнгө бий болгогч ба мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийн хувьд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрч эхэлсэн эсэхийг үнэлэхийг уг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаардана.

ДҮ105. УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн анх удаа мөрдөлтөнд үнэ цэнийн бууралтын гарзын үзүүлэх үр нөлөөг хүлээн зөвшөөрөх хоёр сонголтыг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Эхний сонголт нь тэдгээр хөрөнгийг нөхөгдөх дүн буюу нөхөгдөх үйлчилгээний дүнгээр хэмжих ба төсөөлөн тооцсон өртөг байдлаар түүнийг ашиглах явдал юм. Энэ сонголтыг мөрдсөний үр нөлөө нь үнэ цэнийн бууралтын гарзыг ирээдүйд буцаахгүй байж болно гэсэн утга болохыг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс энэ сонголтыг тохиромжгүй гэж үзсэн.

ДҮ106. Илүү хамааралтай мэдээллээр хангадаг хоёр дахь сонголт нь хөрөнгийг түүний нөхөгдөх дүн буюу нөхөгдөх үйлчилгээний дүнгээр хэмжих ба үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид тайлагнах явдал юм. УСНББОУС3 нь энэ сонголтыг дэмжсэн.

Байгууллага нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөх хугацааг мөрддөг үед хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сорил хийх хугацаа

ДҮ107. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр тухайн хөрөнгийн үнэ цэнийг буцаан залруулахад төвөгтэй байж болно гэж УСНББОУС3 дүгнэсэн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-д шижлсэн өдрөөр оршин байсан эсвэл оршин байгаагүй үнэ цэнийн бууралтад үндэслэх шаардлагатай тийм залруулгын дүнг тодорхойлоход төвөгтэй байж болох юм.

ДҮ108. Үүний улмаас ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дууссан эсвэл холбогдох хөрөнгийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн (аль түрүүнд болох өдөр) өдөр УСНББОУС 21 ба УСНББОУС 26-г гүйцээх горимоор мөрдөхийг УСНББОУС3 зөвшөөрсөн.

*УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж*

ДҮ109. Анх удаа мөрдөж буй байгууллага нь өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тус байгууллага нь тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийн тухайн тайлант болон өмнөх дөрвөн жилийн дүнгүүд, хөтөлбөрийн хөрөнгийн бодит үнэ цэнэ, уг хөтөлбөрийн ашиг, алдагдал болон УСНББОУС 39-ээр гүйцээх горимоор мөрдөхөөр шаардсан тохируулгын талаархи мэдээллээр хангана.

*УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*

ДҮ110. УСНББОУС 28 нь гэрээ байгуулсан өдөр уг нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг түүний өр төлбөрийн болон өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсгүүдээр салган задлахыг байгууллагаас шаарддаг. Эдгээр хоёр хэсгийг салган зааглах нь өртөг зардал ихтэй бөгөөд хэрэв УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, уг нийлмэл хэрэглүүрийн өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг цаашид оршин байхааргүй бол санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллээр хангахгүй гэж дүгнэсэн. Иймээс УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг нь цаашид оршин байхааргүй бол анх удаа мөрдөж буй байгууллага нь өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт хуримтлагдсан хүүг цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгээс салган зааглах шаардлагагүй гэж энэхүү УСНББОУС-д заасан.

*УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт*

ДҮ111. Ихэнх тохиолдолд үнэ цэнийн бууралтын зарчмуудыг буцаах горимоор мөрдөх практик боломжгүй тул санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийн

бууралтыг гүйцээх горимоор тайлагнах хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Энэхүү чөлөөлөлт нь мөнгө бий болгодоггүй хөрөнгө болон мөнгө бий болгогч хөрөнгөнд УСНББОУС 21, УСНББОУС 26-гийн дагуу олгодог чөлөөлөлтийн нөхцөлтэй нийцдэг.

*УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*

ДҮ112. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүр болон түүнээс үүсэх эрсдлийн шинж төрөл, хэмжээний талаархи мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тодруулдаггүй байсан бол ийм мэдээллийг олж авахад өртөг зардал ихтэй тул хэрэгжүүлэх боломжгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ113. Анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол тэрхүү чөлөөлөх хугацаа дууссан буюу холбогдох зүйлсийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс, эсвэл УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) эхлэн тэдгээр санхүүгийн хэрэглүүртэй холбоотой тодруулгын шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөх хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ нь дээрх шалтгаанаар хүлээн зөвшөөрсөн.

ДҮ114. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн тохиолдолд санхүүгийн хэрэглүүрүүдээс үүсэх эрсдлийн шинж төрөл ба хэмжээтэй холбоотойгоор тухайн зэрэгцүүлэгдэх тайлант үед тодруулга хийх мэдээллийг олж авахад өртөг зардал ихтэй, иймээс хэрэгжих боломжгүй учраас уг анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах шаардлагагүй гэдгийг зөвшөөрсөн.

*УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө*

ДҮ115. УСНББОУС-уудаар хүлээн зөвшөөрөхийг шаарддаг бүх хөрөнгө, өр төлбөрийг УСНББОУС-ыг анх мөрдсөн өдрөөр хүлээн зөвшөөрөхийг уг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаарддаг. Биет бус хөрөнгийн хувьд гарсан ба зардал гэж анх хүлээн зөвшөөрсөн зарлагыг хожим нь биет бус хөрөнгийн өртгийн нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрөхгүй гэж УСНББОУС 31-д заасан.

ДҮ116. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдөхөөс өмнө, биет бус хөрөнгүүдийн хувьд гарсан өртгийг нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу зардал болгосон байж болох тул УСНББОУС 31-д заасан, хүлээн зөвшөөрөлтийн болон бусад шалгуурыг (өөрөөр хэлбэл, хөрөнгийн, түүнчлэн тухайн хөрөнгөнд хамааруулж болох бөгөөд уг байгууллагад орох ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн тодорхойлж болох хяналт) хангаж байгаа бүх биет бус хөрөнгийг, хэдийгээр тэдгээрийн өртгийг УСНББОУС-ыг мөрдөхөөс өмнө зардал болгосон ч гэсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөхийг уг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрөх хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Гэхдээ УСНББОУС-ыг мөрдсөн өдөр тухайн хөрөнгийн өртгийн талаархи найдвартай мэдээлэл

бэлэн боломжтой байгаа бөгөөд идэвхитэй зах зээл оршин байгаа зөвхөн тийм тохиолдолд уг хөрөнгийг биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг батлан илэрхийлсэн.

Бусад байгууллагууд дахь хувь оролцоо

ДҮ117. УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 7, *Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт*, УСНББОУС 8, *Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо*, түүнчлэн 2015 оны 01 дүгээр сард гаргаж, 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс хүчин төгөлдөр болох бөгөөд дурдсан хугацаанаас өмнө мөрдөж болох УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ыг УСНББОУС 33-д лавлагаа болгон дурдах хэрэгтэй эсэхийг УСНББОУС3 харгалзан үзсэн. УСНББОУС 33-ыг 2015 оны 01 дүгээр сард гаргасан тул УСНББОУС 33-ыг мөрдөх ба 3 жилийн чөлөөлөлтийн хугацааг ашиглах сонголт хийсэн байгууллагууд нь тэдгээр шилжилтийн хугацаа дуусах хүзртэлх хугацаанд УСНББОУС 34-УСНББОУС 36-г мөрдөх шаардлагатай болоход хүрнэ гэж УСНББОУС3 тэмдэглэсэн. 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө УСНББОУС 33-ыг мөрдөж буй байгууллагууд нь үүнээс хойш богино хугацааны дараа УСНББОУС 34-УСНББОУС 36-д цаашид шилжих шаардлагатай УСНББОУС 6-УСНББОУС 8-ыг мөрдөх магадлал маш багатай гэсэн үзэл бодлыг УСНББОУС3 илэрхийлсэн. Иймээс УСНББОУС3 нь УСНББОУС 6-УСНББОУС 8-тай холбоотой заалтуудыг УСНББОУС 33-д оруулах хэрэггүй гэж дүгнэсэн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 33-т хийсэн хянан засварлалт**

ДҮ118. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р параграфт* нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

ХЗУ1. Энэхүү Хэрэгжүүлэх Заавар Удирдамжийн зорилго нь УСНББОУС 33-ын шаардлагуудын зарим төлөв байдлыг үлгэрчлэн харуулахад оршино.

### **УСНББОУС-ыг мөрдсөн өдөр**

ХЗУ2. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь байгууллага өөрийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ аккруэл суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдсөн өдөр юм.

ХЗУ3. Энэхүү УСНББОУС-ыг мөрдөхийн өмнө, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-д шилжихэд зохих ёсоор бэлтгэсэн байвал зохино. УСНББОУС3-өөс гаргасан Судалгаа 14, *Нягтлан Бодох Бүртгэлийн Аккруэл Суурьт Шилжилт: Засгийн Газар болон Засгийн Газрын Байгууллагуудад Зориулсан Заавар Удирдамж*-д дурдсан, заавар удирдамж нь анх удаа мөрдөж буй байгууллага аккруэл суурьт УСНББОУС-д шилжилтийг төлөвлөхөд туслалцаа үзүүлж болох юм. Энэхүү УСНББОУС-д заасан чөлөөлөлтийн нөхцөл нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөх иж бүрэн замын зураглал биш, харин мөрдөх үйл явцын эцсийн үе шат гэж ойлгох хэрэгтэй.

ХЗУ4. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллагын аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөх сонголт хийсэн ба түүний дагуу өөрийн шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг, эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг толилуулсан тайлант үеийн эхлэл юм. Жишээлбэл; байгууллага нь 20X1 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үеийн хувьд аккруэл суурьт УСНББОУС-ыг хугацаанд 20X1 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөх сонголт хийсэн. Тэгвэл УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь 20X1 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болно.

### **Шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан**

ХЗУ5. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д заасан, чөлөөлөх нөхцлүүдийн аль нэгийг мөрдөх сонголт хийж болох юм. УСНББОУС 33-д заасан, зарим чөлөөлөх нөхцөл нь уг анх удаа мөрдөж буй байгууллагын санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-д нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөө үзүүлдэг (Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөх ба/буюу мөрдөхөөр сонголт хийхийг уг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаардах шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон заалтуудыг Хавсралт А-д жагсаан харуулсан бөгөөд үнэн зөв толилуулга, түүнчлэн аккруэл суурьт УСНББОУС-д нийцсэн гэж мэдэгдэх уг анх удаа мөрдөж буй байгууллагын чадвар боломжид нөлөөлөх эсэхийг энд үлгэрчлэн харуулсан).

- ХЗУ6. УСНББОУС 33-д заасан, чөлөөлөх нөхцлүүдийг мөрдсөний дараа, анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэсэн бүрэн тодорхой мэдэгдлийг гаргаж чадахгүй тул аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараах анхны тайлант үед толилуулсан санхүүгийн тайланг “шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан” гэж нэрлэдэг.
- ХЗУ7. Жишээлбэл; аккруэл суурьт УСНББОУС-ыг 20Х1 оны 01 дүгээр сарын 1-нд мөрдөж эхлэхдээ, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог шилжилтийн үеийн нөхцлийг мөрдсөн бол тус байгууллага нь өөрийн анхны тайлант үеийн эцэст, өөрөөр хэлбэл 20Х1 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэсэн бүрэн тодорхой мэдэгдэл гаргах боломжгүй байна. Иймээс анхны тайлант үеийн хувьд бэлтгэсэн санхүүгийн тайланг “шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан” гэж нэрлэнэ.
- ХЗУ8. Ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дуусах ба/буюу холбогдох зүйлсийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл тухайн шилжилтийн хугацаанд толилуулсан санхүүгийн тайланг “шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан” гэж нэрлэнэ.

*Шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэх үеийн тайлан бэлтгэх суурь*

- ХЗУ9. УСНББОУС 33-ын 27-р параграфт заасанчлан, УСНББОУС 33-ын нэг буюу хэд хэдэн чөлөөлөх нөхцлүүдийг мөрдөх сонголт хийсэн уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 1-ээр шаардсан, аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэсэн бүрэн тодорхой мэдэгдлийг хийх боломжгүй байж болох юм. “Тайлан бэлтгэх суурь”-ийг тухайн санхүүгийн тайланд толилуулснаар ийм нөхцөл байдлыг уг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд шилжилтийн үеийн туршид анхааруулан мэдэгдэнэ.
- ХЗУ10. Жишээлбэл; анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжихдээ гурван жилийн чөлөөлөлт олгодог шилжилтийн үеийн нөхцлийг мөрдөх сонголт хийсэн бол тухайн шилжилтийн үеийн туршид дараах тайлбарыг уг санхүүгийн тайланд “тайлан бэлтгэх суурь” параграфт тусган харуулж болох юм:

*Тайлан бэлтгэх суурь*

Уг санхүүгийн тайланг аккруэл суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ын дагуу бэлтгэсэн. УСНББОУС 33 нь зарим хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх ба хэмжихэд гурав хүртэлх жилийн чөлөөлөх хугацааг уг анх удаа мөрдөж буй байгууллагад олгодог.

Аккруэл суурт УСНББОУС-д шилжихдээ, Х улсын секторын байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд энэхүү шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг. Иймээс тус байгууллага нь энэхүү тайлант үеийн хувьд шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн гэсэн бүрэн тодорхой мэдэгдлийг гаргаж болохгүй юм. Х улсын секторын байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг 20Х3 оны байдлаар хүлээн зөвшөөрч, хэмжих санаа зорилготой байна.

### **УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан**

ХЗУ11. Анх удаа мөрдөж буй байгууллагын УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан нь аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн гэсэн бүрэн тодорхой мэдэгдлийг хийж, толилуулсан түүний анхны иж бүрэн санхүүгийн тайлан юм.

ХЗУ12. Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх тийм чөлөөлөлт олгосон УСНББОУС 33-ын нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу холбогдох зүйлсийг хүлээн зөвшөөрч, хэмжих болон холбогдох мэдээллийг зохих УСНББОУС-ын дагуу толилуулж, тодруулах (аль түүрүүнд болох өдөр) хүртэл уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-тай нийцсэн өөрийн анхны санхүүгийн тайланг бэлтгэх боломжгүй байдаг.

ХЗУ13. ХЗУ5-р параграфт дурдсан жишээг цааш үргэлжлүүлвэл, зарим үндсэн хөрөнгийн зүйлсийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог шилжилтийн үеийн нөхцлүүдийн хугацаа нь гурван жилийн дараа, өөрөөр хэлбэл 20Х3 оны 12 дугаар сарын 31-нд дуусна. Тус байгууллага нь үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх УСНББОУС 33-д заасан, шилжилтийн үеийн өөр бусад чөлөөлөх нөхцлүүдийг ашиглаагүй бөгөөд үндсэн хөрөнгийн зүйлсийг тухайн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрч, хэмжсэн гэж үзвэл уг анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг 20Х3 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үед толилуулна.

ХЗУ14. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь үнэн зөв толилуулга болон аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөх УСНББОУС 33-д заасан, шилжилтийн үеийн аливаа чөлөөлөх нөхцлийг мөрдөөгүй бол түүний аккруэл суурт анхны санхүүгийн тайлан нь мөн түүний УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан байна.

Үлгэрчлэн харуулвал:

**Цаг хугацаа – УСНББОУС-ыг анх мөрдсөн өдөр (тус байгууллага нь зарим хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд шилжилтийн үеийн гурван жилийн чөлөөлөлтийг ашиглах сонголт хийсэн гэж үзье)**

## АККРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

Байгууллага нь УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартыг Анх Удаа Мөрдөх*-ийг дагаж мөрдсөнөөр аккруэл суурьт УСНББОУС-ыг 20Х0 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдсөн.


Анх удаа мөрдөж буй байгууллага нь үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд гурван жилийн чөлөөлөлтийн хугацааг ашиглах сонголт хийсэн. Тус байгууллага нь өөр бусад чөлөөлтийн хугацааг мөрддөггүй гэж үзье. Мөн уг байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулахгүй байх сонголт хийсэн.

Анх удаа мөрдөж буй байгууллага нь бүх үндсэн хөрөнгөө 20Х2 оны 12 дугаар сарын 31-нээр хүлээн зөвшөөрдөг.



АККРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

2 дахь тайлант үеийн эхлэл 20X1.01.01 3 дахь тайлант үеийн эхлэл 20X2.01.01



Мөрсөн өдөр 20X0.01.01	1 дэх тайлант үеийн эцэс 20X0.12.31	2 дахь тайлант үеийн эцэс 20X1.12.31	3 дахь тайлант үеийн эцэс 20X2.12.31
<p><b>Жил 1</b></p> <p><u>Жил 1 (20X0.12.31-д дуусгавар болсон) – Шилжилтийн үеийн УСНББОУС-тай нийцсэн анхны санхүүгийн тайлан</u> Акрүүл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэж болохгүй</p> <p>Дараах тайланг толилуулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>* Эхлэлийн санхүүгийн байдлын тайлан-20X0.01.01</li> <li>* Санхүүгийн байдлын тайлан-20X1.01.01</li> <li>* Санхүүгийн үр дүнгийн тайлан-20X0.12.31-нээр дуусгавар болсон</li> <li>* Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан-20X0.12.31-нээр дуусгавар болсон</li> <li>* Мөнгөн гүйцэтгэлийн тайлан-20X0.12.31-нээр дуусгавар болсон</li> <li>* Төсөв, гүйцэтгэлийн мэдээллийн зэрэгцүүлэлтийн тайлан-20X0.12.31-нээр дуусгавар болсон (мэдээллийг толилуулахаар сонгосон бодлогоос хамааран уг анх удаа мөрдөж буй байгууллага нь жилийн санхүүгийн тайланд нэмэлт багана оруулж болно)</li> </ul> <p>Дараах зүйлсийг тодруулгад толилуулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>* НББ-ийн өмнөх сууриас өөрчлөгдсөн өөрчлөлтийн тохируулгын тайлан (УСНББОУС 17-гоос бусад бүх УСНББОУС-ын мөрдөлттэй холбоотой тохируулгыг тусгах)</li> </ul> <p>Тэмдэглэл: Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээлэл толилуулах сонголт хийсэн бол дараах тайланг толилуулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>* Эхлэлийн санхүүгийн байдлын тайлан-19X0.01.01</li> <li>* Санхүүгийн байдлын тайлан-19X0.12.31 ба 20X0.12.31</li> <li>* Санхүүгийн үр дүнгийн тайлан-19X0.12.31 ба 20X0.12.31-нээр дуусгавар болсон</li> <li>* Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан-19X0.12.31 ба 20X0.12.31-нээр дуусгавар болсон</li> <li>* Мөнгөн гүйцэтгэлийн тайлан-19X0.12.31 ба 20X0.12.31-нээр дуусгавар болсон</li> <li>* Төсөв, гүйцэтгэлийн мэдээллийн зэрэгцүүлэлтийн тайлан-19X0.12.31 ба 20X0.12.31-нээр дуусгавар болсон</li> </ul>	<p><b>Жил 2 (20X1.12.31-д дуусгавар болсон) – Шилжилтийн үеийн УСНББОУС-тай нийцсэн анхны санхүүгийн тайлан Акрүүл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэж болохгүй</b></p> <p>20X1.12.31 ба 20X0.12.31-ний аль алины хувьд дараах тайланг толилуулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>* Санхүүгийн байдлын тайлан</li> <li>* Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан</li> <li>* Мөнгөн гүйцэтгэлийн тайлан</li> </ul> <p>Зөвхөн 20X1.12.31-нээр төсөв, гүйцэтгэлийн мэдээллийн зэрэгцүүлэлтийн тайланг толилуулна (мэдээллийг толилуулахаар сонгосон бодлогоос хамааран уг анх удаа мөрдөж буй байгууллага нь жилийн санхүүгийн тайланд нэмэлт багана оруулж болно)</p>	<p><b>Жил 3 (20X2.12.31-д дуусгавар болсон) –УСНББОУС-тай нийцсэн анхны санхүүгийн тайлан УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэж болно</b></p> <p>20X2.12.31 ба 20X1.12.31-ний аль алины хувьд дараах тайланг толилуулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>* Санхүүгийн байдлын тайлан</li> <li>* Санхүүгийн үр дүнгийн тайлан</li> <li>* Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан</li> <li>* Мөнгөн гүйцэтгэлийн тайлан</li> </ul> <p>Зөвхөн 20X2.12.31-нээр төсөв, гүйцэтгэлийн мэдээллийн зэрэгцүүлэлтийн тайланг толилуулна (мэдээллийг толилуулахаар сонгосон бодлогоос хамааран уг анх удаа мөрдөж буй байгууллага нь жилийн санхүүгийн тайланд нэмэлт багана оруулж болно)</p> <p>Дараах зүйлсийг тодруулгад толилуулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>* Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийн тулд хийсэн залруулгад хамаарах тохируулгын тайлан</li> </ul>	

**Тооцоолол**

ХЗУ15. Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийж байсан тооцоолол нь алдаатай гэсэн бодит нотолгоо байхаас бусад тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллагын УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр УСНББОУС-д нийцүүлэн хийсэн тооцоолол нь тэрхүү өмнөх суурийн дагуу түүний зэрэгцүүлэгдэх тайлант үеийн эцэст хийсэн (нягтлан бодох бүртгэлийн бодлогын аливаа зөрүүтэй байдлыг тусгах залруулгын дараах) тооцоололтой нийцсэн байхыг УСНББОУС 33-ын 23-р параграфтаар шаардсан. Анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн тооцооллын талаархи мэдээллийг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойш хүлээн авч болох юм. 24-р параграфт заасанчлан, анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм мэдээлэл хүлээн авалтыг УСНББОУС 14, *Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал*-ын дагуу тайлант үеийн дараах үл тохируулагдах үйл явдалтай ижил арга замаар авч үзнэ.

ХЗУ16. Жишээлбэл; анх удаа мөрдөж буй байгууллагын УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь 20Х4 оны 01 дүгээр сарын 01 бөгөөд 20Х4 оны 7 дугаар сарын 15-нд хүлээн авсан шинэ мэдээлэл нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу 20Х3 оны 12 дугаар сарын 31-нээр хийсэн тооцооллыг засварлахыг шаарддаг гэж үзье. Уг анх удаа мөрдөж буй байгууллага нь энэ шинэ мэдээллийг (нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын аливаа зөрүүтэй байдал эсвэл уг тооцоолол алдаатай гэсэн бодит нотолгоо байгаа тул тооцооллыг залруулах шаардлагатайгаас бусад тохиолдолд) эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа тусгахгүй. Харин анх удаа мөрдөж буй байгууллага нь энэ шинэ мэдээллийг 20Х4 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлнт жилийн ашиг, алдагдалд тусгана.

**Хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөлт олгодог шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд**

ХЗУ17. УСНББОУС 33 нь зарим хөрөнгө, өр төлбөрийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлүүдийг уг анх удаа мөрдөж буй байгууллагад олгодог. Анх удаа мөрдөж буй байгууллага нь энэхүү чөлөөлөлтийн нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тус байгууллага нь ийм хөрөнгийг зохих УСНББОУС-ын дагуу тайлагнаж, ангилахдаа эрхийн бүртгэл, гэрээ болон бусад адилтгах хэлцлүүдийг харгалзан үзэж, шинжилнэ.

ХЗУ18. Жишээлбэл; анх удаа мөрдөж буй байгууллага нь 20Х1 оны 01 дүгээр сарын 01-нд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөх үедээ олон төрлийн үндсэн хөрөнгийг хянадаг байсан гэж үзье. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн шилжилтийн хугацаанд үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байх чөлөөлөлтийн нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тус байгууллага нь 20Х1 оны 01 дүгээр сарын 01-нээс 20Х3 оны 12 дугаар сарын 31 хүртэлх шилжилтийн хугацаанд үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжиж болно. Үндсэн хөрөнгийг жишээлбэл, 20Х2 оны 4 дүгээр сарын 01-нд хүлээн зөвшөөрсөн

бол уг анх удаа мөрдөж буй байгууллага нь 20Х2 оны 01 дүгээр сарын 01-ний хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдлийг тохируулна. УСНББОУС 33-ын 142-р параграфтаар шаардсанчлан, анх удаа мөрдөж буй байгууллага нь 20Х2 оны 4 дүгээр сарын 01-нд хүлээн зөвшөөрсөн үндсэн хөрөнгийн хувьд 20Х1 оны 12 дугаар сарын 31-нээрх хуримтлагдсан ашиг, алдагдлын (өөрөөр хэлбэл, 20Х2 оны 01 дүгээр сарын 01-нээрх эхний үлдэгдэл) тохируулгын тайлангөөрийн санхүүгийн тайлангийн тодруулгын нэг хэсэг байдлаар харуулна.

ХЗУ19. Анх удаа мөрдөж буй байгууллага нь гурван жилийн чөлөөлтийн хугацааны давуу талыг ашигладаг бол УСНББОУС-ын шаардлагад нийцүүлэх шаардлагатайгаас бусад тохиолдолд тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрч байсан аливаа хөрөнгө, өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөхгүй. Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн аливаа тохируулгыг түүнийг хийсэн тайлант үеийн хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд тэрхүү шилжилтийн хугацаанд тусгана.

*Санхүүгийн түрээсийн хөрөнгө ба санхүүгийн түрээсийн өр төлбөрийг тайлагнах*

ХЗУ20. Анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн түрээсийн хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд санхүүгийн түрээсийн хөрөнгөтэй холбоотой шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн хугацаа дуусах буюу уг санхүүгийн түрээсийн хөрөнгийг УСНББОУС 13-ын дагуу хүлээн зөвшөөрөх хүртэл санхүүгийн түрээсийн өр төлбөрт хамаарах хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг мөн даган мөрдөхгүй байж болно.

ХЗУ21. Жишээлбэл; аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу 20Х1 оны 01 дүгээр сарын 01-нд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн түрээсийн гэрээний зүйл болох автомашинтай байсан гэж үзье. Анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн автомашиныг хүлээн зөвшөөрөхгүй байх гурван жилийн чөлөөлөлтийн хугацаа олгодог шилжилтийн нөхцлийн давуу талыг ашигладаг. Чөлөөлөлтийн хугацаа дууссан өдөр буюу 20Х3 оны 12 дугаар сарын 31-нд уг автомашиныг хүлээн зөвшөөрсөн. УСНББОУС 33 нь 20Х3 оны 12 дугаар сарын 31-нд, өөрөөр хэлбэл тухайн санхүүгийн түрээсийн хөрөнгийг (автомашин) зөвхөн хүлээн зөвшөөрсөн өдөр тэрхүү автомашинд хамаарах санхүүгийн түрээсийн өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг тус байгууллагаас шаарддаг.

*Үндсэн хөрөнгийн анхны өртөгт тусгасан нөөцийн хүлээн зөвшөөрөлт*

ХЗУ22. Зарим тохиолдолд үндсэн хөрөнгийн барьж байгуулалт буюу ашиглалтанд оруулалт нь үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах үүргийг тухайн байгууллагад хүлээлгэдэг гэдгийг УСНББОУС 17-д заасан байдаг. Тухайн үндсэн хөрөнгийн анхны өртөгт тусган оруулах

тэрхүү үр дүн болох нөөцийг хүлээн зөвшөөрч, хэмжихдээ УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийг мөрдөхийг уг байгууллагаас шаарддаг.

ХЗУ23. УСНББОУС 33 нь ийм өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөх нөхцөл олгодог. УСНББОУС 17-д заасан, ийм чөлөөлөлтийн хугацаа дуусах ба/буюу хамаарах хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжих ба холбогдох мэдээллийг УСНББОУС 17-гийн дагуу санхүүгийн тайланд толилуулж, тодруулах (аль түрүүнд болох өдөр) хүртэл тухайн үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын анхны тооцоололтой холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг уг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрдөг.

ХЗУ24. Жишээлбэл; байгууллага нь 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөн ба төрийн өмчит цөмийн эрчим хүчний станцыг хүлээн зөвшөөрөхгүй байх гурван жилийн чөлөөлөлтийн хугацаа олгосон УСНББОУС 33-д заасан, шилжилтийн нөхцлийн давуу талыг ашигладаг. Уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн хөрөнгийн төсөөлөн тооцсон өртгийг 20X3 оны 6 дугаар сарын 30-нд тодорхойлж, мөн өдөр хөрөнгийг 1,000,000 ТН-ээр хүлээн зөвшөөрсөн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр тус үйлдвэрийг ашиглалтаас хасах 500,000 ТН-ийн үүрэгтэй гэдгээ УСНББОУС 19-ийн дагуу тодорхойлсон. Хөрөнгийг хүлээн зөвшөөрөх үед буюу 20X3 оны 6 дугаар сарын 30-нд уг үүргийн тооцоолсон дүн 550,000 ТН байсан.

ХЗУ25. УСНББОУС 33 нь тухайн хөрөнгийг буулгаж задлах болон байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулахтай холбоотой үүргийг 20X3 оны 6 дугаар сарын 30-нд, өөрөөр хэлбэл тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн өдөр зөвхөн хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжихийг уг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаардана. Тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн өдрөөрх уг анх удаа мөрдөж буй байгууллагын үүргийг тусгах дүн буюу 550,000 ТН-ээр өр төлбөрийг хэмжинэ. 20X2 оны 6 дугаар сарын 30-нд хүлээн зөвшөөрсөн үүргийн болон холбогдох хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тохируулгын тайланг 20X2 оны 12 дугаар сарын 31-нээрх хуримтлагдсан ашиг, алдагдалд (өөрөөр хэлбэл, 20X3 оны 01 дүгээр сарын 01-ний эхний үлдэгдэлд) санхүүгийн тайлангийн тодруулгын нэг хэсэг байдлаар харуулна.

#### *Шалгуур хангах хөрөнгийн хувьд гарсан зээлийн өртөг*

ХЗУ26. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зээлийн өртгийг зөвшөөрөгдсөн сонголтот аргын дагуу тайлагнах сонголт хийсэн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө, тухайн шалгуур хангах хөрөнгүүдийн хувьд гарсан аливаа зээлийн өртөгт тус байгууллага нь УСНББОУС 5, *Зээлийн Өртөг*-т заасан шаардлагуудыг буцаах горимоор мөрдөхийг УСНББОУС 33-ын 90-р параграфтаар шаардсан байдаг.

ХЗУ27. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд гурван жилийн шилжилтийн хугацаа олгодог чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд шалгуур хангах хөрөнгийн хувьд гарсан зээлийн өртгийн капиталжуулалтыг тухайн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн дараа эхлэхийг зөвшөөрснөөр УСНББОУС 33-ын 44-р параграф нь энэхүү шаардлагаас чөлөөлдөг.

ХЗУ28. Жишээлбэл; шалгуур хангах хөрөнгийн хувьд гарсан зээлийн өртгийг тайлагнахдаа уг анх удаа мөрдөж буй байгууллага нь зөвшөөрөгдсөн сонголтот аргыг ашигладаг. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь 20X1 оны 01 дүгээр сарын 01 юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө гарсан зээлийн өртгийг 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд 500,000 ТН гэж тодорхойлсон ба дараагийн хоёр тайлант үеийн эцэст гарсан зээлийн өртөг нь тус бүр 20,000 ТН ба 30,000 ТН байсан. Мөн түүнчлэн, анх удаа мөрдөж буй байгууллага нь үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд гурван жилийн шилжилтийн хугацаа олгодог чөлөөлөх нөхцлийг ашигладаг ба үүний үр дүнд уг үндсэн хөрөнгийг хоёр дахь тайлант үеийн эцэст 1,000,000 ТН-ээр хүлээн зөвшөөрсөн.

20X2 оны эцсийн байдлаар, тухайн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн үндсэн хөрөнгийн зүйлийн дүн нь 1,030,000 ТН (1,000,000 ТН + 30,000 ТН) байсан. Уг үндсэн хөрөнгийн зүйлийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө гарсан зээлийн өртөг, өөрөөр хэлбэл 500,000 ТН ба 20,000 ТН-ийг уг шалгуур хангах хөрөнгийн өртгийн нэг хэсэг байдлаар тусган оруулахгүй.

### **Зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах**

ХЗУ29. УСНББОУС 33-ын 78-р параграф нь шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланд эсвэл энэхүү УСНББОУС-ын дагуу толилуулсан УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулахыг байгууллагаас шаардахгүй боловч дэмждэг. Зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах шийдвэр нь зөвхөн тухайн толилуулсан мэдээллийн хэмжээ төдийгүй УСНББОУС-ыг мөрдөх өдөрт бас нөлөөлдөг.

### ***УСНББОУС-ыг мөрдсөн өдөр***

ХЗУ30. Үлгэрчлэн харуулвал: Анх удаа мөрдөж буй байгууллагын аккруэл суурьт анхны тайлант үеийн эцэс нь 20X5 оны 12 дугаар сарын 31 юм. Уг анх удаа мөрдөж буй байгууллага нь зөвхөн нэг жилийн санхүүгийн тайландаа зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулахаар шийдвэрлэсэн (УСНББОУС 33-ын 78-р параграфыг үзнэ үү). Иймээс түүний УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь уг зэрэгцүүлэгдэх тайлант үеийн эхэн, өөрөөр хэлбэл 20X4 оны 01 дүгээр сарын 01 (буюу адилтгах өдөр нь 20X3 оны 12 дугаар сарын 31) байна.

*Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг бэлтгэх сонголт хийсэн тохиолдолд толилуулсан мэдээлэл*

ХЗУ31. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг бэлтгэх сонголт хийсэн тохиолдолд 20X5 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар

болсон тайлант үеүдэд хүчин төгөлдөр байгаа аккруэл суурт УСНББОУС-ыг дараах зүйлсийн хувьд мөрдөхийг тус байгууллагаас шаардана:

- (а) 20Х4 оны 01 дүгээр сарын 01-нд өөрийн аккруэл суурт эхлэлийн санхүүгийн байдлын тайланг бэлтгэж, толилуулах; ба
- (б) Доорх зүйлсийг бэлтгэж, толилуулах:
  - (i) 20Х5 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан (үүн дотроо, 20Х4 оны зэрэгцүүлэгдэх дүнгүүд);
  - (ii) Санхүүгийн үр дүнгийн тайлан (үүн дотроо, 20Х4 оны зэрэгцүүлэгдэх дүнгүүд);
  - (iii) 20Х5 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (үүн дотроо, 20Х4 оны зэрэгцүүлэгдэх дүнгүүд);
  - (iv) 20Х5 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон мөнгөн гүйлгээний тайлан (үүн дотроо, 20Х4 оны зэрэгцүүлэгдэх дүнгүүд);
  - (v) Тодруулга (үүн дотроо, 20Х4 оны зэрэгцүүлэгдэх дүнгүүд);
  - (vi) 20Х5 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт;
  - (vii) 142-р параграфт заасан, тохируулгын тайлан.

*Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг бэлтгэхгүй байх сонголт хийсэн тохиолдолд*

ХЗУ32. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг бэлтгэхгүй байх сонголт хийсэн тохиолдолд 20Х5 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үеүдэд хүчин төгөлдөр байгаа аккруэл суурт УСНББОУС-ыг дараах зүйлсийн хувьд мөрдөхийг тус байгууллагаас шаардана:

- (а) 20Х5 оны 01 дүгээр сарын 01-нд өөрийн аккруэл суурт эхлэлийн санхүүгийн байдлын тайланг бэлтгэж, толилуулах; ба
- (б) Доорх зүйлсийг бэлтгэж, толилуулах:
  - (i) 20Х5 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан;
  - (ii) 20Х5 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн үр дүнгийн тайлан;
  - (iii) 20Х5 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан;
  - (iv) 20Х5 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн мөнгөн гүйлгээний тайлан;
  - (v) Тодруулга;

- (vi) 20X5 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт;
- (vii) 142-р параграфт заасан, тохируулгын тайлан.

*Чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацааг ашиглах*

ХЗУ33. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтээс чөлөөлөх нөхцлүүдийн давуу талыг ашигладаг тохиолдолд тус байгууллага нь хүлээн зөвшөөрсөн ба/буюу хэмжсэн зүйлсийн талаархи найдвартай ба хамааралтай мэдээлэл бэлэн боломжтой байгаа тохиолдолд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн дараах, тайлант үеүдийн хувьд зэрэгцүүлэгдэх мэдээллийг зөвхөн залруулахыг УСНББОУС 33-аар шаарддаг.

ХЗУ34. Үлгэрчлэн харуулвал: Анх удаа мөрдөж буй байгууллагын аккруэл суурьт анхны тайлант үеийн эцэс нь 20X2 оны 12 дугаар сарын 31 юм. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө оруулалтын хүлээн зөвшөөрөлтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгодог шилжилтийн нөхцлийг мөрдсөн. 20X3 оны эцэст уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрч, 20X3 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайланд тусгасан. 20X3 онд хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн талаархи найдвартай ба хамааралтай мэдээлэл бэлэн боломжтой байвал уг анх удаа мөрдөж буй байгууллага нь (өөрөөр хэлбэл, 20X2 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үед) толилуулсан зэрэгцүүлэгдэх мэдээллээ тохируулна.

**Тохируулгыг толилуулах**

ХЗУ35. УСНББОУС 33-ын 142-р параграф нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан цэвэр хөрөнгө/өмчийн эцсийн үлдэгдлийг уг шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд УСНББОУС-ын дагуу тайлагнасан цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдэл болгох тохируулгын тайланг толилуулахыг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаарддаг. Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан ашиг, алдагдлыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх ашиг, алдагдлын эхний үлдэгдэл болгох тохируулгын тайланг толилуулдаг.

ХЗУ36. Жишээлбэл; нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккруэл суурийг өмнө нь мөрдөж байсан анх удаа мөрдөж буй байгууллага нь 20X4 оны 01 дүгээр сарын 01-нд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөж эхэлсэн бөгөөд УСНББОУС 33-д зөвшөөрсний дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн. УСНББОУС 33-ын 142, 143-р параграфт заасанчлан, анх удаа мөрдөж буй байгууллага нь 20X4 оны 01 дүгээр сарын 01-нээрх эхлэлийн санхүүгийн байдлын тайлан түүнчлэн, хамааралтай бол санхүүгийн үр дүнгийн дахин илэрхийлсэн зэрэгцүүлэгдэх

тайланд хийсэн материаллаг залруулгыг ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгох хангалттай дэлгэрэнгүй мэдээллээр хангах тохируулгын тайланг өөрийн шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулна.

- ХЗУ37. Тухайн зүйлийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг анх удаа мөрдөж буй байгууллага нь өмнөх санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй ба/буюу хэмжээгүй байсан боловч уг тайлант үед хүлээн зөвшөөрч, хэмжсэн зүйлсийн талаархи тохируулгын тайланг толилуулахыг 146-р параграфтаар бас шаардсан байдаг.
- ХЗУ38. ХЗУ29-р параграфын жишээг цааш үргэлжлүүлвэл, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг гурван жилийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй байхыг зөвшөөрдөг, УСНББОУС 33-д заасан, чөлөөлөх нөхцлийг мөрдсөн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь энэ чөлөөлөх нөхцлийг мөрдөх ба тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг гурван жилийн эцэст, өөрөөр хэлбэл 20Х4 оны 12 дугаар сарын 31-нд зөвхөн хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрөхдөө 20Х4 оны 01 дүгээр сарын 01-нээрх хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд тохируулга хийдэг тул 146-р параграф нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа хийсэн тохируулгыг ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгох тохируулгын тайланг 20Х4 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулахыг уг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаарддаг.

### **Төсөөлөн тооцсон өртөг**

ХЗУ39. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байх гурван жилийн чөлөөлөлтийн хугацаа олгодог шилжилтийн нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд тус байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх худалдан авалтын өртөг буюу элэгдэл тооцсон өртгийн орлуулагч байдлаар төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлохыг УСНББОУС 33-аар зөвшөөрсөн байдаг. Гэвч тухайн хөрөнгө, өр төлбөрийн түүхэн өртгийн талаархи мэдээлэл бэлэн боломжтой байхгүй зөвхөн тийм үед төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлж болох юм. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр тэдгээр хөрөнгийг анх хэмжсэн үед, эсвэл зарим хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн хугацаа дууссан тохиолдолд тус байгууллага нь түүний үр нөлөөг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- (а) Төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлсон тайлант үеийн эхлэлийн санхүүгийн байдлын тайлан дахь хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдлийн тохируулга байдлаар; эсвэл



АККРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

- (б) Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 17 эсвэл УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-д заасан, дахин үнэлгээний загварыг ашигладаг бол дахин үнэлгээний нэмэгдэлд.

Үлгэрчлэн харуулвал:

Х улсын секторын байгууллага нь 20Х4 оны 01 дүгээр сарын 01-нд аккурэл суурт УСНББОУС-ыг мөрдсөн ба хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хэмжихийн тулд төсөөлөн тооцсон өртгийг ашигласан. Төсөөлөн тооцсон өртгийг ашигласнаар, уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр 1,800,000 ТН-ээр үнэлсэн. Х улсын секторын байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулахгүй байх сонголт хийсэн.

**20Х4 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

	Хяналт тавигч байгууллагын эздэд хамааруулж болох		Нийт цэвэр хөрөнгө/өмч-ТН
	Хуримтлагдсан ашиг/алдагдал-ТН	Бусад нөөц-ТН	
Эхний үлдэгдэл, 20Х4 оны 01-р сарын 01	210,000	10,000	220,000
УСНББОУС 33-ын дагуу төсөөлөн тооцсон өртгөөр хэмжсэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дүн (Тодруулга 34-ийг үзнэ үү)	1,500,000	-	1,500,000
Дахин илэрхийлсэн эхний үлдэгдэл, 20Х4 оны 01-р сарын 01	1,710,000	10,000	1,720,000
Тайлант үеийн ашиг	5,000	-	5,000
Эцсийн үлдэгдэл, 20Х4 оны 12-р сарын 31	1,715,000	10,000	1,725,000

**Х улсын секторын байгууллагын 20Х4 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайлангийн тодруулга**

**Тодруулга 34 – Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**

	<b>20Х4 оны 12-р сарын 31-ТН</b>
Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн эхний үлдэгдэл	300,000
УСНББОУС 33-ын дагуу 20Х4 оны 01-р сарын 01-нд төсөөлөн тооцсон өртгөөр хэмжсэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	1,500,000
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн 20Х4 оны 01-р сарын 01-нд дахин илэрхийлсэн эхний үлдэгдэл	1,800,000
Нэмэгдэлт	.....

**Аккурэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх УСНББОУС 33-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл**

Х улсын секторын байгууллага нь 20Х4 оны 01 дүгээр сарын 01-нд аккурэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн ба зарим хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн талаархи өртгийн найдвартай мэдээлэл бэлэн боломжтой байгаагүй тул уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хэмжихдээ төсөөлөн тооцсон өртгийг ашигласан. Иймээс Х улсын секторын байгууллага нь 20Х4 оны 01-р сарын 01-нд уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн эхний үлдэгдлийг 1,500,000 ТН-ийн нэмэлт үнэ цэнээр дахин илэрхийлсэн.

**Тодруулга 54 –20Х4 оны 01-р сарын 01-ний цэвэр хөрөнгө/өмчийн болон ашиг, алдагдлын тохируулга**

*20Х4 оны 01-р сарын 01-ний цэвэр хөрөнгө/өмчийн тохируулга*

	<b>20Х4 оны 01-р сарын 01-ний цэвэр хөрөнгө/өмч-ТН</b>
Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан 20Х4 оны 01-р сарын 01-ний цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдэл	220,000
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг төсөөлөн тооцсон өртгөөр хүлээн зөвшөөрөлт (Тодруулга 34-ийг үзнэ үү)	1,500,000
Цэвэр хөрөнгө/өмчийн 20Х4 оны 01-р сарын 01-ний дахин илэрхийлсэн эхний үлдэгдэл	<b>1,720,000</b>

20Х4 оны 01-р сарын 01-ний ашиг, алдагдлын тохируулга

	<b>20Х4 оны 01-р сарын 01-ний ашиг, алдагдал-ТН</b>
<i>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан 20Х3 оны 12-р сарын 31-ний ашиг, алдагдал</i>	210,000
<i>Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг төсөөлөн тооцсон өртгөөр хүлээн зөвшөөрөлт (Тодруулга 34-ийг үзнэ үү)</i>	1,500,000
<i>20Х4 оны 01-р сарын 01-нд дахин илэрхийлсэн ашиг, алдагдал</i>	<b>1,710,000</b>

*Шилжилтийн хугацаанд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлох*

ХЗУ40. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг УСНББОУС 33-ын чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд уг гурван жилийн шилжилтийн хугацааны доторх дурын хугацааны туршид тухайн хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлж болно гэж УСНББОУС-д заасан.

ХЗУ41. Хэрэв хамааралтай бол дараагийн тайлант үеийн элэгдэл ба хорогдуулга нь төсөөлөн тооцсон өртөгт үндэслэх бөгөөд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс, эсвэл ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дууссан ба/буюу холбогдох зүйлсийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн (аль түрүүнд болох өдөр) өдрөөс эхэлнэ.

ХЗУ42. Жишээлбэл; анх удаа мөрдөж буй байгууллага нь 20Х1 оны 01 дүгээр сарын 01-нээс УСНББОУС-ыг мөрдсөн бөгөөд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд гурван жилийн чөлөөлөлт олгодог шилжилтийн нөхцлийг мөрддөг. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг анх удаа мөрдөж буй байгууллагад тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн түүхэн өртгийн талаархи найдвартай мэдээлэл байгаагүй учраас тус байгууллага нь тэрхүү хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлохоор шийдвэрлэсэн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь чөлөөлөлтийн нөхцлийг мөрдсөн хоёр дахь тайлант үед (өөрөөр хэлбэл, 20Х2 он) тус хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлсон. Анх удаа мөрдөж буй байгууллага нь 20Х2 оны 01-р сарын 01-ний хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдлийг тохируулах замаар уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрөхдөө 20Х2 онд тодорхойлсон тэрхүү төсөөлөн тооцсон өртгийг ашиглахыг УСНББОУС 33-аар зөвшөөрдөг. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 16-г мөрдөх үедээ дараагийн тайлант үеийн хэмжилтийн суурь болгон өртгийн загварыг ашиглах сонголт хийсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг үнэлэх ба дараагийн тайлант

үеийн элэгдлийг тодорхойлохын тулд 20Х2 оны 01-р сарын 01-нд тодорхойлсон уг төсөөлөн тооцсон өртгийг ашиглана.

### **УСНББОУС 5, Зээлийн Өртөг**

ХЗУ43. Байгууллага нь 20Х3 оны 01-р сарын 01-нд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн ба зээлийн өртгийг тайлагнахдаа зөвшөөрөгдсөн сонголтот аргыг ашигладаг. Тухайн хөрөнгийн худалдан авалтанд шууд хамааруулж болох зээлийн өртөг нь 525,000 ТН байсан бөгөөд үүний 500,000 ТН нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөхөөс өмнө гарсан, харин 25,000 ТН нь 20Х3 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон эхний тайлант жилд гарсан. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зөвшөөрөгдсөн сонголтот аргыг ашигладаг тохиолдолд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөхөөс өмнө гарсан аливаа зээлийн өртгийг буцаах горимоор хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 33-ын 90-р параграфтаар шаардсан байдаг. Иймээс уг 500,000 ТН-ийг 20Х3 оны 01-р сарын 01-ний эхлэлийн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн тухайн хөрөнгийн өртөгт капиталжуулна.

ХЗУ44. Байгууллага нь бенчмарк аргыг мөрдөх сонголт хийсэн бол УСНББОУС 33-ын 88-р параграф нь уг анх удаа мөрдөж буй байгууллага тэрхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогоо буцаах горимоор тайлагнахыг дэмжих боловч ингэж тайлагнахыг заавал шаардахгүй. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг гүйцээх горимоор мөрдөх сонголт хийсэн бол тус байгууллага нь 20Х3 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үеийн санхүүгийн үр дүнгийн тайланд ердөө 25,000 ТН-ийг зардал болгоно.

### **УСНББОУС 9, Арилжааны Ажил Гүйлгээний Орлого**

ХЗУ45. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 9-ийн дагуу орлого гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хараахан хангаагүй байгаа дүнг (жишээлбэл; орлого гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй борлуулалтын мөнгөн орлогыг) хүлээн авсан бол тус байгууллага нь тэрхүү хүлээн авсан дүнг эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд уг өр төлбөрийн дүнг тухайн хүлээн авсан дүнгээр хэмжинэ. УСНББОУС 9-д заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдсан тохиолдолд тус байгууллага нь өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрч, өөрийн санхүүгийн үр дүнгийн тайландаа орлогыг хүлээн зөвшөөрнө.

### **УСНББОУС 10, Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал**

ХЗУ46. Анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн бүртгэлийн валют ба толилуулгын валютыг тодорхойлохдоо УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-г дагаж мөрдөнө. Анх удаа мөрдөж буй байгууллага нь эхлэлийн санхүүгийн байдлын тайлангаа бэлтгэх үедээ бүртгэлийн эсвэл толилуулгын валютын эдийн засаг нь хэт инфляцитай байх аливаа тайлант үеүдэд УСНББОУС 10, *Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал*-ыг мөрдөнө.

ХЗУ47. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 33-ын 64-76-р параграфт заасан, чөлөөлөх нөхцлүүдийг ашиглах сонголт хийсэн тохиолдолд уг дахин үнэлсэн дүн эсвэл бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн дараах тайлант үеүдэд УСНББОУС 10-ыг мөрдөнө.

#### **УСНББОУС14, Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал**

ХЗУ48. ХЗУ49-р параграфт зааснаас бусад тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь дараах зүйлсийг тодорхойлохдоо УСНББОУС 14, *Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал*-ыг мөрдөнө:

- (a) Шилжилтийн өдрийн дараа гарч тохиолдсон үйл явдлыг түүний эхлэлийн санхүүгийн байдлын тайланд тусгасан эсэх; ба
- (б) Хэрэв хамааралтай бол шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан дахь зэрэгцүүлэгдэх дүнгүүд нь уг зэрэгцүүлэгдэх тайлант үеийн эцсээс хойш гарч тохиолдсон үйл явдлыг тусгасан эсэх.

ХЗУ49. Тооцооллын өөрчлөлт нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх (хамааралтай бол тухайн зэрэгцүүлэгдэх тайлант үеийн эцэст) залруулагдах эсвэл үл залруулагдах үйл явдал эсэхийг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тодорхойлох үедээ УСНББОУС 14-д заасан зарчмуудад зарим засвар өөрчлөлт хийхийг УСНББОУС 33-ын 23-26-р параграфтаар шаардсан байдаг. Ийм засвар өөрчлөлтийг доорх Жишээ 1 ба 2-т үлгэрчлэн харуулсан. Харин доорх жишээ 3-ын хувьд УСНББОУС 33-ын 23-26-р параграф нь УСНББОУС 14-ийн зарчмуудад засвар өөрчлөлт хийхийг шаардахгүй юм.

- (a) Жишээ 1 - Анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь нь УСНББОУС-д нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого ашиглаж, УСНББОУС-ыг мөрдсөн өдөр тэдгээрийн ижил төсөөтэй зүйлсийг тооцоолохыг шаарддаг. Энэ жишээний хувьд, нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийж байсан тооцоолол нь алдаатай гэсэн бодит нотолгоо байхаас бусад тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр УСНББОУС-д нийцүүлэн хийсэн тооцоолол нь тэрхүү өмнөх суурийн дагуу хийсэн тооцоололтой нийцсэн байх шаардлагатай (УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-г үзнэ үү). Анх удаа мөрдөж буй байгууллага нь эдгээр тооцоололд хожим хийсэн засвар өөрчлөлтийг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр оршин байсан нөхцөл байдлын талаархи цаашдын нотолгоог хүлээн авсны үр дүн болох залруулагдах үйл явдал байдлаар биш, харин засвар өөрчлөлт хийсэн тухайн тайлант үеийн үйл явдал байдлаар тайлагнана.
- (б) Жишээ 2 - Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр тэдгээрийн ижил төсөөтэй зүйлсийг тооцоолохыг шаарддаг боловч уг анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой үл нийцэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг ашигласнаар тэдгээр тооцооллыг УСНББОУС-

ын дагуу хийсэн. Энэ тохиолдолд УСНББОУС-ын дагуу хийсэн уг тооцоолол нь тэрхүү өдөр, нягтлан бодох бүртгэлийн бодлогын зөрүүтэй байдлыг тусгасны дараах, нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн тооцоололтой (тэдгээр тооцоолол алдаатай гэсэн бодит нотолгоо байхаас бусад тохиолдолд) нийцсэн байх шаардлагатай. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зөрүүтэй байдлын хувьд хийгдэх тохируулгыг эхлэлийн санхүүгийн байдлын тайланд тусгадаг. Жишээ 1-д дурдсанчлан, анх удаа мөрдөж буй байгууллага нь эдгээр тооцоололд хожим хийсэн засвар өөрчлөлтийг түүнийг хийсэн тухайн тайлант үеийн үйл явдал байдлаар тайлагнана.

Жишээлбэл; нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хэмжилт нь дискаунтчлаагүй суурьт үндэслэсэн байхаас бусад тохиолдолд тэрхүү нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь нь УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-д нийцсэн сууриар нөөцийг хүлээн зөвшөөрч, хэмжихийг уг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаарддаг байж болох юм. Энэ жишээнд, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн эдгээр тооцооллыг УСНББОУС 19-өөр шаардсан, дискаунтчилсан хэмжилтийг хийх орц болгон ашигладаг.

- (в) Жишээ 3 - Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь нь ижил төсөөтэй зүйлсийн тооцооллыг уг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр хийхийг шаарддаггүй. Тухайн өдөр УСНББОУС-ын дагуу хийсэн тооцоолол нь тэрхүү өдрөөр оршин буй нөхцөл байдлыг тусгадаг. Тухайлбал; УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх зах зээлийн үнэ, хүүний түвшин, гадаад валютын ханшийн талаархи тооцоолол нь уг өдрөөрх зах зээлийн нөхцөл байдлыг тусгадаг. Энэ нь УСНББОУС 14-д заасан, тайлангийн өдрийн дараах залруулагдах үйл явдал ба үл залруулагдах үйл явдлын хоорондох ялгаатай байдалтай нийцдэг.

ХЗУ50. Үлгэрчлэн харуулвал: А байгууллагын шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан нь уг анх удаа мөрдөж буй байгууллага зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн 20X5 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үеийн санхүүгийн тайлан юм. Дараах ажил гүйлгээ ба үйл явдлыг А байгууллагын 20X3 ба 20X4 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үеийн санхүүгийн тайланд уг нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тодруулсан:

- (а) Хуримтлагдсан зардал ба нөөцийн тооцооллыг эдгээр өдрүүдээр хийсэн;
- (б) Тус байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийг мөнгөн сууриар тайлагнасан; ба
- (в) 20X4 оны 9 дүгээр сард гарч тохиолдсон үйл явдлын улмаас үүссэн шүүхийн маргааны хувьд нөөц хүлээн зөвшөөрөөгүй. Уг шүүхийн маргаан 20X5 оны 6 дугаар сарын 30-нд шийдвэрлэгдэж, А байгууллага нь 1,000 ТН-ийг төлөх шаардлагатай болсон бөгөөд үүнийг 20X5 оны 7 дугаар сарын 10-нд төлсөн.

Хуримтлагдсан зардал ба нөөцийн хувьд нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу 20Х3 он ба 20Х4 оны 12 дугаар сарын 31-нд хийх тооцоолол нь түүний нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцсэн сууриар УСНББОУС-ын дагуу хийгдсэн гэж А байгууллага нь өөрийн шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэх үедээ дүгнэсэн. Хэдийгээр зарим хуримтлагдсан зардал ба нөөцийг илүү, заримыг дутуу тооцоолсон байж болох боловч А байгууллага нь түүний тооцоолол ул үндэслэлтэй, иймээс алдаа гаргаагүй гэж дүгнэсэн. Иймээс эдгээр илүү ба дутуу тооцооллын тайлагнал нь УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу хийгдэх тооцооллын ердийн залруулгатай холбоотой байна.

### Шаардлагуудыг мөрдөх

20Х4 оны 01 дүгээр сарын 01-ний эхлэлийн санхүүгийн байдлын тайлан ба 20Х4 оны 12 дугаар сарын 31-ний зэрэгцүүлэгдэх санхүүгийн байдлын тайланг бэлтгэхдээ, А байгууллага нь:

- (a) Хуримтлагдсан зардал ба нөөцийн өмнөх тооцооллыг залруулахгүй;
- (b) Тэтгэврийн хөтөлбөрийг УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн дагуу тайлагнахад шаардлагатай тооцооллыг (актуар таамаглал хэлбэрээр) хийсэн. А байгууллагын 20Х4 оны 01 дүгээр сарын 01 ба 20Х4 оны 12 дугаар сарын 31-нээрх актуар таамаглал нь эдгээр өдрөөс хойш үүссэн нөхцөл байдлыг тусгадаггүй. Жишээлбэл; А байгууллагын:
  - (i) тэтгэврийн хөтөлбөрийн болон нөөцийн хувьд 20Х4 оны 01 дүгээр сарын 01 ба 20Х4 оны 12 дугаар сарын 31-нээрх дискаунтын хувь нь эдгээр өдрөөрх зах зээлийн нөхцөл байдлыг тусгадаг; ба
  - (ii) Ажилтнуудын ирээдүйн эргэц хөдөлгөөний талаархи 20Х4 оны 01 дүгээр сарын 01 ба 20Х4 оны 12 дугаар сарын 31-нээрх актуар таамаглалууд нь тэтгэврийн хөтөлбөрийг 20Х5 онд цомхотгосны үр дүнд ажилтнуудын тооцоолсон эргэц хөдөлгөөн мэдэгдэхүйц өсөх гэх мэт тэдгээр өдрөөс хойш үүссэн нөхцөл байдлыг тусган илэрхийлэхгүй.

20Х4 оны 12 дугаар сарын 31-нээрх шүүхийн маргааны тайлагнал нь А байгууллага өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу уг өдөр нөөцийг хүлээн зөвшөөрөөгүй учир шалтгаанаас хамаарна.

**Таамаглал 1** - Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь нь УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-тэй нийцдэг. Харин А байгууллага нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдахгүй гэж дүгнэсэн. Энэ тохиолдолд А байгууллагын УСНББОУС-ын дагуу хийсэн таамаглал нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн таамаглалтай нийцдэг. Иймээс А байгууллага нь 20Х4 оны 12 дугаар сарын 31-нд нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй.

**Таамаглал 2** – А байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурь нь УСНББОУС 19-тэй нийцдэггүй байсан. Иймээс А байгууллага нь УСНББОУС 19-ийн дагуу тооцооллыг хийсэн. Тус байгууллага нь бэлэн боломжтой байгаа бүх

нотолгоог, үүн дотроо тайлангийн өдрийн дараах үйл явдлаар илэрхийлэгдэх аливаа нэмэлт нотолгоог харгалзан үзсэнээр тухайн тайлант үеийн эцэст үүрэг хүлээсэн эсэхээ УСНББОУС 19-ийн дагуу тодорхойлно. Үүнтэй адилаар, тус байгууллага нь тайлангийн өдөр одоогийн үүрэгтэй байсан гэдгээ батлан харуулсан бол уг тайлангийн өдрийн дараах шүүхийн маргааны шийдвэрлэлт нь УСНББОУС 14, *Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал*-д заасанчлан, тайлангийн өдрийн дараах залруулагдах үйл явдал болно. Энэ тохиолдолд шүүхийн маргааны шийдвэрлэлт нь 20X4 оны 9 дүгээр сард (шүүхийн маргаан үүсэхэд хүргэсэн уг үйл явдал гарч тохиолдсон үед) тус байгууллага өр төлбөртэй байсан гэдгийг батлан харуулна. Иймээс А байгууллага нь 20X4 оны 12 дугаар сарын 31-нд нөөцийг хүлээн зөвшөөрнө. 20X5 оны 7 дугаар сарын 10-нд төлсөн 1,000 ТН-ийг А байгууллага нь УСНББОУС 19-тэй нийцсэн ба 20X4 оны 12 дугаар сарын 31-нээрх зах зээлийн нөхцөл байдлыг тусгасан дискаунтын хувь ашиглан түүний өнөөгийн үнэ цэнэ болгон дискаунтчилснаар тэрхүү нөөцийг хэмждэг.

ХЗУ51. УСНББОУС 33-ын 23-26-р параграф нь тухайн тодорхой өдрөөр оршин буй нөхцөл байдлуудын дагуу ангилал буюу хэмжилт хийх суурь үндэслэл болох бусад УСНББОУС-ын шаардлагуудыг үгүйсгэдэггүй. Үүний жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Санхүүгийн түрээс ба үйл ажиллагааны түрээсийн хоорондох ялгаа (УСНББОУС 13, *Түрээс*-ийг үзнэ үү);
- (б) Санхүүгийн өр төлбөр ба өмчийн хэрэглүүрийн хоорондох ялгаа (УСНББОУС 28, *Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга*-ыг үзнэ үү).

### **УСНББОУС 13, Түрээс**

ХЗУ52. УСНББОУС 33-ын 95-р параграф, УСНББОУС 13-ын 18-р параграфт заасанчлан, түрээслэгч буюу түрээслүүлэгч нь түрээс үүссэн өдөр оршин буй нөхцөл байдлуудад үндэслэн түрээсийг уг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр үйл ажиллагааны түрээс эсвэл санхүүгийн түрээс гэж ангилдаг. Зарим тохиолдолд түрээслэгч ба түрээслүүлэгч нь тэрхүү түрээс үүссэн өдрөөр хэрэв уг өөрчлөгдсөн нөхцөл хүчин төгөлдөр байсан бол УСНББОУС 13-ын дагуу өөр ангилал хийхэд хүргэх тийм байдлаар тухайн түрээсийг шинэчлэхээс бусад байдлаар түүний нөхцлийг өөрчлөхөөр харилцан тохиролцож болох юм. Хэрэв ингэж тохиролцсон бол тэрхүү өөрчлөн засварласан гэрээг аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойшхи түрээсийн хугацааны туршид шинэ гэрээтэй адилтган авч үзнэ. Харин тооцооллын өөрчлөлт (жишээлбэл; түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийн эдийн засгийн ашиглалтын хугацаа буюу үлдэх өртгийн тооцооллын өөрчлөлт) эсвэл нөхцөл байдлын өөрчлөлт (жишээлбэл; түрээслэгч нь түрээсийн төлбөрөө төлөхгүй байх) нь түрээсийн шинэ ангилал үүсэхэд хүргэхгүй.

### **УСНББОУС 17, Үндсэн хөрөнгө**

ХЗУ53. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурьт нийцсэн элэгдлийн арга ба элэгдлийн хувь хэмжээ нь УСНББОУС-тай нийцсэн гэж үзэж болохоор байвал тус байгууллага нь тооцоолсон



ашиглалтын хугацаа буюу элэгдлийн аргын аливаа өөрчлөлтийг тэрхүү тооцооллын өөрчлөлт хийсэн өдрөөс эхлэн гүйцээх горимоор тайлагнана (УСНББОУС 33-ын 22, 26-р параграф болон УСНББОУС 17-гийн 76-р параграф). Гэвч анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурьт нийцсэн элэгдлийн арга ба элэгдлийн хувь хэмжээ нь УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөх элэгдлийн арга болон хувь хэмжээнээс зарим тохиолдолд өөр байж болох юм (жишээлбэл; тэдгээр нь тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны ул үндэслэлтэй тооцооллыг тусган илэрхийлээгүй байх). Хэрэв ийм зөрүүтэй байдал нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй бол байгууллага нь УСНББОУС-тай нийцүүлэхийн тулд эхлэлийн санхүүгийн байдлын тайлан дахь хуримтлагдсан элэгдлийг буцаах горимоор тохируулна.

ХЗУ54. Анх удаа мөрдөж буй байгууллага нь дараах дүнгүүдийн аль нэгийг үндсэн хөрөнгийн төсөөлөн тооцсон өртөг болгон ашиглах сонголт хийж болох юм:

- (a) УСНББОУС (УСНББОУС 33-ын 67-р параграф)-ыг мөрдсөн өдрөөрх бодит үнэ цэнэ, энэ тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 33-ын 148-р параграфтаар шаардсан тодруулгыг хийнэ; эсвэл
- (б) УСНББОУС 33-ын 67-р параграфын шалгуурыг хангасан, нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн дахин үнэлгээ.

ХЗУ55. Дараагийн тайлант үеийн элэгдэл нь уг төсөөлөн тооцсон өртөгт үндэслэх бөгөөд анх удаа мөрдөж буй байгууллага нь төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлсон өдрөөс, хэрэв уг анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгийг гурван жилийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу хөрөнгийг УСНББОУС 17-гийн дагуу хүлээн зөвшөөрсөн өдрөөс (аль түүрүүнд болох өдрөөс) эхлэн элэгдлийг тооцоолно.

ХЗУ56. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь үндсэн хөрөнгийн зарим эсвэл бүх ангийн хувьд УСНББОУС 17-д заасан, дахин үнэлгээний загварыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого болгон сонгосон бол тус байгууллага нь дахин үнэлгээний хуримтлагдсан нэмэгдлийг цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэг байдлаар толилуулна. УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх дахин үнэлгээний нэмэгдэл нь тэрхүү өдрөөрх уг хөрөнгийн дансны үнэ ба түүний өртөг эсвэл төсөөлөн тооцсон өртгийн хоорондох зэрэгцүүлэлтэд үндэслэдэг. Төсөөлөн тооцсон өртөг нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх, эсвэл хэрэв уг анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгийг гурван жилийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу хөрөнгийг УСНББОУС 17-гийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөрх (аль түүрүүнд болох өдрөөрх) бодит үнэ цэнэ байх тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 33-ын 148-р параграфтаар шаардсан тодруулгыг хийнэ.

ХЗУ57. Анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн дахин үнэлгээ нь УСНББОУС 33-ын 67-р эсвэл 69-р параграфт заасан, шалгуурыг хангахгүй бол уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү дахин үнэлсэн хөрөнгийг өөрийн эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа дараах сууриудын аль нэгд үндэслэн хэмжинэ:

- (а) УСНББОУС 17-д заасан өртгийн загварын дагуух өртөг (буюу төсөөлөн тооцсон өртөг)-өөс аливаа хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн;
- (б) Төсөөлөн тооцсон өртөг, энэ нь бодит үнэ цэнийн талаархи зах зээлд суурилсан нотолгоо бэлэн боломжтой байхгүй тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх, эсвэл хэрэв уг анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгийг гурван жилийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу хөрөнгийг тухайн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөрх (аль түрүүнд болох өдрөөрх) бодит үнэ цэнэ буюу түүнтэй адилтгах дүн байна;
- (в) УСНББОУС 17-д заасан, дахин үнэлгээний загварыг уг байгууллага нь тухайн нэг ангийн үндсэн хөрөнгийн бүх зүйлсийн хувьд УСНББОУС-д нийцсэн, өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого болгон мөрддөг бол дахин үнэлсэн дүн.

ХЗУ58. УСНББОУС 17 нь тухайн үндсэн хөрөнгийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг нэг бүрийг тусад нь элэгдүүлэхийг шаарддаг. Гэвч УСНББОУС 17 нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд хэмжилтийн нэгжийг өөрөөр хэлбэл, үндсэн хөрөнгийн зүйлийг юу бүрдүүлэх эсэхийг тодорхойлон заагаагүй. Иймээс тухайн байгууллагын тодорхой нөхцөл байдалд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хэрэглэхдээ шүүн тунгаалт хийх шаардлагатай (18 ба 59-р параграф).

### **УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж**

ХЗУ59. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, анх удаа мөрдөж буй байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг хэмжихдээ УСНББОУС 39-ийг мөрдөх бөгөөд уг хөтөлбөр үүссэн өдрөөс УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хүртэлх, эсвэл хэрэв уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг гурван жилийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дуусах буюу тэрхүү тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг УСНББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих өдөр (аль түрүүнд болох өдөр) хүртэл хуримтлагдсан бүх актуар олз, гарзыг хүлээн зөвшөөрнө.

ХЗУ60. УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт

хугацааны бусад тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дуусах буюу тэрхүү тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг УСНББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих өдрөөрх (аль түрүүнд болох өдрөөрх) уг анх удаа мөрдөж буй байгууллагын актуар таамаглалууд нь зэрэгцүүлэгдэх тайлант үеийн эцэст (анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 33-ын 78-р параграфын дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн бол) нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн таамаглалууд (нягтлан бодох бүртгэлийн бодлогын аливаа зөрүүтэй байдлыг тусгах тохируулгын дараа) алдаа гэсэн бодит нотолгоо байхаас бусад тохиолдолд (УСНББОУС 33-ын 23-р параграф) тэдгээр актуар таамаглалуудтай нийцсэн байна. Тэдгээр таамаглалд хожим хийсэн аливаа засвар өөрчлөлт нь анх удаа мөрдөж буй байгууллага тэрхүү засвар өөрчлөлтийг хийсэн тухайн тайлант үеийн актуар олз, гарз болно.

- ХЗУ61. Түүний нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу шаардлагагүй байсан боловч анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг УСНББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөр (аль түрүүнд болох өдрөөр) актуар таамаглалуудыг хийх шаардлагатай байж болно. Ийм актуар таамаглалууд нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг УСНББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрийн (аль түрүүнд болох өдрийн) дараа үүссэн нөхцөл байдлыг тусган илэрхийлэхгүй. Харин УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг УСНББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөрх (аль түрүүнд болох өдрөөрх) дискаунтын хувь болон хөтөлбөрийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь тухайн өдрөөрх зах зээлийн нөхцөл байдлыг тусган илэрхийлнэ. Үүнтэй адилаар, УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг УСНББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөр (аль түрүүнд болох өдрөөр)

ажилтнуудын ирээдүйн эргэц хөдөлгөөний түвшний талаар уг анх удаа мөрдөж буй байгууллагын хийсэн актуар таамаглалууд нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг УСНББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) хойш хийгдсэн тухайн тэтгэврийн хөтөлбөрийн цомхтголын үр дүнд ажилтнуудын эргэц хөдөлгөөний тооцоолсон түвшинд гарсан мэдэгдэхүйц нэмэгдэлтийг тусган илэрхийлэхгүй (УСНББОУС 33-ын 23-р параграф).

ХЗУ62. Анх удаа мөрдөж буй байгууллагын шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан эсвэл түүний УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан нь ажилтнуудын тэтгэмжийн үүргийн хэмжилтийг олон тохиолдолд (анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 33-ын 78-р параграфын дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн тохиолдолд) гурван өдрөөр тусган харуулдаг. Үүнд: анхны тайлант үеийн эцэс, зэрэгцүүлэгдэх санхүүгийн байдлын тайлангийн өдөр (анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн тохиолдолд), УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг УСНББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр). Анх удаа мөрдөж буй байгууллага нь ажил эрхлэлтийн дараах материаллаг бүх тэтгэмжийн үүргийн хэмжилтэнд мэргэшсэн актуарч оролцуулахыг УСНББОУС 39-өөр дэмжсэн байдаг. Өртөг зардлаа багасгахын тулд анх удаа мөрдөж буй байгууллага нь нарийвчилсан актуар үнэлгээг нэг буюу хоёр өдрөөр хийхийг уг мэргэшсэн актуарчаас хүсэх ба тэрхүү үнэлгээг өмнөх эсвэл дараах бусад өдрүүдэд шилжүүлэн ашиглаж болох юм. Ингэж өмнөх эсвэл дараах хугацаанд шилжүүлсэн аливаа үнэлгээ нь тэдгээр өдрүүдийн хооронд гарсан аливаа материаллаг ажил гүйлгээ болон бусад материаллаг үйл явдлыг (үүн дотроо, зах зээлийн үнийн болон хүүний түвшний өөрчлөлтийг) тусгасан байна (УСНББОУС 25-ын 68-р параграф).

### **УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт ба УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт**

ХЗУ63. Анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 21 ба УСНББОУС 26-гийн шаардлагуудыг аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийг гурван жилийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс эхлэн гүйцээх горимоор мөрдөхийг УСНББОУС 33-ын 98

ба 108-р параграфтаар шаардсан байдаг. Жишээлбэл; байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ыг 20Х1 оны 01 дүгээр сарын 01-нд мөрдсөн ба үндсэн хөрөнгийн зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байх гурван жилийн шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг тохиолдолд үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг (а) 20Х3 оны 12 дугаар сарын 31 (өөрөөр хэлбэл, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийн хугацаа дууссан өдөр), эсвэл (б) хэрэв үндсэн хөрөнгийн зүйлийг шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрч, хэмждэг бол тэрхүү хүлээн зөвшөөрөлтийн дараах өдөр (аль түрүүнд болох өдөр) хүртэл үнэлэхийг тус байгууллагаас шаардахгүй.

ХЗУ64. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог шилжилтийн нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тухайн хөрөнгийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) үнэ цэнийн бууралтын гарзыг тус байгууллага хүлээн зөвшөөрөх (ба ийм аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хэмжих) эсэхийг тодорхойлоход ашигласан тооцоолол нь зэрэгцүүлэгдэх тайлант үеийн эцэст (анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 33-ын 78-р параграфын дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн бол) нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн тооцооллууд (нягтлан бодох бүртгэлийн бодлогын аливаа зөрүүтэй байдлыг тусгах тохируулгын дараа) алдаа гэсэн бодит нотолгоо байхаас бусад тохиолдолд (УСНББОУС 33-ын 23 ба 24-р параграф) тэдгээр өмнөх тооцоололтой нийцсэн байна. Тэдгээр тооцоололд хожим хийсэн аливаа засвар өөрчлөлтийг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү засвар өөрчлөлтийг хийсэн тухайн тайлант үеийн үйл явдал байдлаар тайлагнана.

ХЗУ65. УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог шилжилтийн үеийн нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү хөрөнгийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөр (аль түрүүнд болох өдрөөр) үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх (ба ийм аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хэмжих) шаардлагатай эсэхийг үнэлэхдээ, уг анх удаа мөрдөж буй байгууллага нь түүний нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу шаардлагагүй байсан тооцооллыг тэрхүү өдрөөр хийх шаардлагатай болж болох юм. Ийм тооцоолол ба таамаглалууд нь шилжилтийн өдрийн, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү хөрөнгийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрийн (аль түрүүнд болох өдрийн) дараа үүссэн нөхцөл байдлыг тусган илэрхийлэхгүй (УСНББОУС 33-ын 25-р параграф).

## **УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга**

ХЗУ66. Санхүүгийн хэрэглүүр нь УСНББОУС 28 (13 ба 35-р параграф) дахь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг анх хангасан тохиолдолд анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү өдрийн дараах (тухайн хэрэглүүрийн нөхцлийн өөрчлөлтөөс бусад) үйл явдлуудыг харгалзан үзэхгүй бөгөөд уг гаргасан санхүүгийн хэрэглүүрийг (эсвэл гаргасан нийлмэл хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг) холбогдох гэрээний мөн чанарын дагуу өөрийн эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа санхүүгийн өр төлбөр эсвэл цэвэр хөрөнгө/өмч гэж ангилахдаа УСНББОУС 28-д заасан шалгуурыг ашиглана.

## **УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт**

### *Хүлээн зөвшөөрөлт*

ХЗУ67. УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) өмнө, нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу үл хүлээн зөвшөөрсөн бөгөөд анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 33-ын 116-р параграфыг мөрдөх сонголт хийгээгүй (УСНББОУС 33-ын 115 ба 116-р параграфыг үзнүү) тийм үүсмэл бус санхүүгийн хөрөнгө ба үүсмэл бус санхүүгийн өр төлбөрөөс бусад, УСНББОУС 29-д заасан хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангадаг боловч УСНББОУС 29-д заасан үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хараахан хангаагүй бүх санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг (үүн дотроо, бүх үүсмэл хэрэглүүрийг) уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хүлээн зөвшөөрнө.

ХЗУ68. Жишээлбэл; УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө гарч тохиолдсон үнэт цаасжуулалт, шилжүүлэг болон үл хүлээн зөвшөөрөлтийн бусад ажил гүйлгээ нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байвал УСНББОУС 33-ын 116-р параграфыг мөрддөггүй анх удаа мөрдөж буй байгууллага нь эдгээр ажил гүйлгээгээр шилжүүлсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй. Харин УСНББОУС-д шилжсэн өдрөөс, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) хойши дараагийн шилжүүлгийн хувьд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн үнэт цаасжуулалтын хэлцэл буюу үл хүлээн зөвшөөрөлтийн бусад хэлцлийг ашиглаж байгаа бол тэдгээр дараагийн шилжүүлгүүд нь УСНББОУС 29-д заасан, үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж буй зөвхөн тийм тохиолдолд үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангана.

*Дагалдах үүсмэл хэрэглүүр*

ХЗУ69. УСНББОУС 29 нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг үндсэн гэрээнээс салган тусгаарлахыг уг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаарддаг тохиолдолд УСНББОУС 29-д заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг тухайн хэрэглүүр анх хангасан өдрөөрх түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн анхны дансны үнэ нь тэрхүү өдрөөрх нөхцөл байдлыг тусган илэрхийлдэг (УСНББОУС 29-ийн 12-р параграф). Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь дагалдах үүсмэл хэрэглүүр ба үндсэн гэрээний анхны дансны үнүүдийг найдвартай тодорхойлж чадахгүй бол тус байгууллага нь уг нийт нийлмэл хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ (УСНББОУС 29-ийн 14-р параграф).

*Хэмжилт*

ХЗУ70. Эхлэлийн санхүүгийн байдлын тайлангаа бэлтгэх үедээ уг анх удаа мөрдөж буй байгууллага нь бодит үнэ цэнээр хэмжсэн ба хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг ялган тодорхойлохын тулд УСНББОУС 29-д заасан шалгуурыг ашиглана.

*Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр эсвэл шилжилтийн хугацаанд санхүүгийн хэрэглүүрийн дансны үнийг тохируулах*

ХЗУ71. УСНББОУС 29-ийг зөвхөн мөрдсөний үр дүнд, санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дансны үнэд хийх тохируулгыг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрөх залруулга байдлаар бүртгэнэ. Санхүүгийн баталгааны гэрээ, эсвэл хейжийн хэрэглүүр гэж сонгосон болон үр дүнтэй хейжийн хэрэглүүр байх хэрэглүүрээс бусад, бүх үүсмэл хэрэглүүрийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилдаг учраас тэдгээр үүсмэл хэрэглүүрүүдийн өмнөх дансны үнэ (энэ нь тэг байж болно) ба бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг УСНББОУС 29-ийг анх мөрдсөн санхүүгийн жилийн эхэнд, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) хуримтлагдсан ашиг, алдагдлын үлдэгдлийн залруулга байдлаар хүлээн зөвшөөрнө.

*Хейжийн нягтлан бодох бүртгэл*

ХЗУ72. Хейжийн нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 33-ын 117-119-р параграфт авч үзсэн. УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс, эсвэл хэрэв анх удаа мөрдөж

буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) эхлэн хейжийн харилцаа нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангадаг тохиолдолд хейжийн харилцааны сонголт болон баримтжуулалтыг уг өдөр буюу түүнээс өмнө иж бүрэн болгож дуусах ёстой. Хейжийн харилцааг зөвхөн бүрэн сонгож, баримтжуулсан өдрөөс хейжийн нягтлан бодох бүртгэлийг гүйцээх горимоор мөрдөнө.

ХЗУ73. Бодит үнэ цэнээр хэмждэггүй хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн хейжийн хувьд олз, гарзыг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрдөггүй буюу хойшлуулдаг байж болох юм. Ийм бодит үнэ цэнийн хейжийн хувьд, анх удаа мөрдөж буй байгууллага нь хейжийн зүйлийн дансны үнийг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) тохируулна. Тохируулгыг дараах хоёр дүнгийн аль бага дүнгээр хийнэ:

- (а) Сонгосон, хейж хийсэн эрсдлийг тусгадаг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй байсан хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийн хэсэг; ба
- (б) Сонгосон, хейж хийсэн эрсдлийг тусгадаг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу (i) хүлээн зөвшөөрөөгүй байсан, буюу (ii) санхүүгийн байдлын тайланд хөрөнгө эсвэл өр төлбөр байдлаар хойшлуулсан уг хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийн хэсэг.

ХЗУ74. Анх удаа мөрдөж буй байгууллага нь урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний хейжийн хувьд олз, гарзыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хойшлуулдаг байж болно. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) уг хейж хийсэн урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь өндөр магадлалтай биш боловч гарч тохиолдохоор хүлээгдэж байвал тэрхүү хойшлуулсан нийт олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 29-ийг анх мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу



тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) цэвэр хөрөнгө/өмчид дахин ангилсан аливаа хуримтлагдсан цэвэр олз, гарз нь (а) уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь дараагийн тайлант үед санхүүгийн бус хөрөнгө эсвэл санхүүгийн бус өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд хүргэх, (б) уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөөлөх, эсвэл (в) дараагийн тайлант үед нөхцөл байдал өөрчлөгдөж, уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ цаашид гарч тохиолдохоор хүлээгдэхээргүй болсон ба ингэснээр аливаа холбогдох хуримтлагдсан цэвэр олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчөөс ашиг, алдагдалд дахин ангилах хүртэл цэвэр хөрөнгө/өмчид хэвээр үлдэнэ. Хэдийгээр хейжийн хэрэглүүрийг эзэмшсэн хэвээр байгаа боловч тухайн хейж нь УСНББОУС 29-д заасан, мөнгөн гүйлгээний хейжийн шалгуурыг хангахгүй тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү санхүүгийн хэрэглүүрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдрөөс (аль түрүүнд болох өдрөөс) эхлэн хейжийн нягтлан бодох бүртгэл цаашид тохиромжгүй болдог.

### **УСНББОУС 31, Биет бус хөрөнгө**

ХЗУ75. УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь биет бус хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү биет бус хөрөнгийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) УСНББОУС 31-д заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаагүй бүх биет бус хөрөнгө болон бусад биет бус зүйлсийг уг анх удаа мөрдөж буй байгууллагын эхлэлийн санхүүгийн байдлын тайланд тусгахгүй, харин тухайн өдөр УСНББОУС 31-д заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангадаг бүх биет бус хөрөнгийг толилуулан тусгана.

ХЗУ76. УСНББОУС 31-д заасан шалгуур нь зөвхөн дараах тохиолдолд биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийг байгууллагаас шаарддаг:

- (а) Тухайн хөрөнгөнд хамаарах хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь уг байгууллагад орох нилээд магадлалтай байх;
- (б) Хөрөнгийн өртөг буюу бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах.

УСНББОУС 31 нь дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хувьд илүү тусгайлсан шалгуурыг оруулснаар энэхүү хоёр шалгуурыг цаашид нэмж дэлгэрүүлдэг.

ХЗУ77. Байгууллага нь дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн өртгийг хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангасан өдрөөс эхлэн УСНББОУС 31-ийн 63 ба 66-р параграфын дагуу гүйцээх горимоор капиталжуулдаг. Тухайн зүйл нь

УСНББОУС 31-д заасан, биет бус хөрөнгийн тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангадаг тохиолдолд өмнө нь зардлаар бүртгэсэн биет бус хөрөнгийг байгууллага нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 31-ээр зөвшөөрсөн байдаг. Иймээс дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь биет бус хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигладаг бол ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан буюу тэрхүү биет бус хөрөнгийг УСНББОУС 31-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн өдөр (аль түрүүнд болох өдөр) хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангадаг тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь хэдийгээр холбогдох зарлагыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу зардал гэж хүлээн зөвшөөрсөн ч гэсэн эхлэлийн санхүүгийн байдлын тайландаа тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжинэ.

ХЗУ78. Хэрэв тухайн хөрөнгө нь УСНББОУС 31-д заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хожмын өдөр хүртэл хангахгүй бол түүний өртөг нь тэрхүү хожмын өдрөөс хойш гарсан зарлагуудын нийлбэр байна.

ХЗУ79. ХЗУ76-р параграфт заасан шалгуурыг тусад нь олж эзэмшсэн биет бус хөрөнгөнд бас мөрдөнө. Тухайн хөрөнгийг олж эзэмших шийдвэрийг дэмжихийн тулд тэр үед ээлтгэсэн баримтжуулалт нь ихэнх тохиолдолд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн талаархи үнэлгээг агуулсан байдаг. Мөн түүнчлэн, УСНББОУС 31-ийн 33-р параграфт тайлбарласанчлан, тусад нь олж эзэмшсэн биет бус хөрөнгийн өртгийг ихэвчлэн найдвартай хэмжих боломжтой байдаг.

ХЗУ80. Анх удаа мөрдөж буй байгууллага нь биет бус хөрөнгийн (дотооддоо бий болгосон биет бус хөрөнгөөс бусад) төсөөлөн тооцсон өртөг байдлаар дараах дүнгүүдийн аль нэгийг ашиглах сонголт хийж болох юм:

(а) УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх, эсвэл хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь зарим хөрөнгийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигладаг бол шилжилтийн хугацаанд тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжсэн буюу ийм чөлөөлөлт олгосон нөхцлийн хугацаа дууссан өдрөөрх (аль түрүүнд болох өдрөөрх) бодит үнэ цэнэ (УСНББОУС 33-ын 67-р параграф). Энэ тохиолдолд байгууллага нь УСНББОУС 33-ын 148-р параграфтаар шаардсан тодруулгыг хийнэ; эсвэл

(б) УСНББОУС 33-ын 67-р параграфт заасан шалгуурыг хангадаг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хийсэн дахин үнэлгээ.

ХЗУ81. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурьт нийцсэн хорогдуулгын арга ба хорогдуулгын хувь хэмжээ нь УСНББОУС-тай нийцсэн гэж үзэж болохоор байвал тус байгууллага нь тооцоолсон ашиглалтын хугацаа буюу хорогдуулгын аргын аливаа өөрчлөлтийг тэрхүү тооцооллын өөрчлөлт хийсэн өдрөөс эхлэн гүйцээх горимоор тайлагнана (УСНББОУС 33-ын 23, 24-р параграф болон

УСНББОУС 31-ийн 103-р параграф). Гэвч анх удаа мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурт нийцсэн хорогдуулгын арга ба хорогдуулгын хувь хэмжээ нь УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөх хорогдуулгын арга болон хувь хэмжээнээс зарим тохиолдолд өөр байж болох юм (жишээлбэл; тэдгээр нь тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны ул үндэслэлтэй тооцооллыг тусган илэрхийлээгүй байх). Хэрэв ийм зөрүүтэй байдал нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй бол анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-тай нийцүүлэхийн тулд эхлэлийн санхүүгийн байдлын тайлан дахь хуримтлагдсан хорогдуулгыг буцаах горимоор тохируулна.

### **УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан**

ХЗУ82. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь хяналтанд буй байгууллагыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу нэгтгэдэггүй байсан бол тус байгууллага нь хяналтанд буй байгууллагын хөрөнгө, өр төлбөрийг УСНББОУС-ыг мөрдсөний дараах, түүний аккруэл суурт санхүүгийн тайланд тусгаж байсантай ижил дансны үнээр өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хэмжиж, тусгана. Гэхдээ нэгтгэлийн тохируулга болон уг хяналтанд буй байгууллагыг олж эзэмшсэн улсын секторын нэгдлийн үр нөлөөний хувьд тохируулга хийсний дараах дүнгээр хэмжинэ (УСНББОУС 33-ын 130-р параграф). Хэрэв хяналтанд буй байгууллага нь өөрийн санхүүгийн тайландаа аккруэл суурт УСНББОУС-ыг мөрддөггүй байсан бол өмнөх өгүүлбэрт дурдсан дансны үнэ нь түүний санхүүгийн тайлангийн хувьд УСНББОУС-аар шаардах байсан тийм дүн байна.

*Хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагаас түрүүлж, аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдөх*

Оршил

ХЗУ83. А хяналт тавигч байгууллага нь УСНББОУС-д нийцсэн анхны (нэгтгэсэн) санхүүгийн тайлангаа 20Х5 онд толилуулсан. Байгуулагдсан цагаасаа А хяналт тавигч байгууллагын бүрэн өмчлөлд байгаа Б хяналтанд буй байгууллага нь нэгтгэлийн өдрөөс эхлэн дотоод нэгтгэлийн зорилгоор мэдээллийг аккруэл суурт УСНББОУС-ын дагуу бэлтгэдэг боловч өөрийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг 20Х7 он хүртэл толилуулаагүй.

Шаардлагуудын мөрдөлт

ХЗУ84. Хэрэв Б хяналтанд буй байгууллага нь УСНББОУС 33-ын 129(а) параграфыг мөрддөг бол түүний хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь 20Х6 оны 01 дүгээр сарын 01-ний УСНББОУС-д нийцсэн эхлэлийн санхүүгийн байдлын тайлан ба А хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн аль алинд ижил дүнтэй (нэгтгэлийн горимын тохируулгаас бусад) байх бөгөөд Б хяналтанд буй байгууллагын УСНББОУС-ыг мөрдсөн өдөрт үндэслэнэ.

ХЗУ85. Нөгөө талаас, Б хяналтанд буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өөрийн өдөрт (20Х6 оны 01 дүгээр сар) үндэслэн бүх хөрөнгө, өр төлбөрөө УСНББОУС 33-ын 129(б) параграфын дагуу хэмжинэ. Гэвч Б хяналтанд буй байгууллага 20Х7 онд анх удаа мөрдөж буй байгууллага болж байгаа нь А хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь түүний хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг өөрчлөхгүй.

*Хяналтанд буй байгууллага нь хяналт тавигч байгууллагаас түрүүлж, аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөх*

Оршил

ХЗУ86. В хяналт тавигч байгууллага нь шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн (нэгтгэсэн) санхүүгийн тайлангаа 20Х7 онд толилуулсан. Байгуулагдсан цагаасаа В хяналт тавигч байгууллагын бүрэн өмчлөлд байгаа Г хяналтанд буй байгууллага нь өөрийн шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг 20Х5 онд толилуулсан. 20Х7 он хүртэл Г хяналтанд буй байгууллага нь дотоод нэгтгэлийн зорилгын хувьд мэдээллийг уг В хяналт тавигч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу бэлтгэсэн.

Шаардлагуудын мөрдөлт

ХЗУ87. Г хяналтанд буй байгууллагын 20Х6 оны 01 дүгээр сарын 01-нээрх хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь В хяналт тавигч байгууллагын аккруэл суурьт эхлэлийн (нэгтгэсэн) санхүүгийн байдлын тайлан ба Г хяналтанд буй байгууллагын санхүүгийн тайлангийн аль алинд ижил дүнтэй (нэгтгэлийн горимын тохируулгаас бусад) байх бөгөөд Г хяналтанд буй байгууллагын УСНББОУС-ыг мөрдсөн өдөрт үндэслэнэ. В хяналтанд буй байгууллага 20Х7 онд анх удаа мөрдөж буй байгууллага болж байгаа нь тэдгээр дансны үнийг өөрчлөхгүй (УСНББОУС 33-ын 129-р параграф).

ХЗУ88. УСНББОУС 33-ын 129 ба 130-р параграф нь дараах шаардлагуудыг үгүйсгэхгүй:

- (а) УСНББОУС 33-ын 129 ба 130-р параграфт хамааралгүй бүх хрөнгө, өр төлбөрийг хэмжих УСНББОУС 33-ын бусад үлдсэн шаардлагууд.
- (б) Анх удаа мөрдөж буй байгууллагын УСНББОУС-д шилжсэн өдрөөр энэ УСНББОУС-аар шаардах бүх тодруулгыг бэлтгэх шаардлага.

ХЗУ89. Хяналтанд буй байгууллага нь өөрийн хяналт тавигч байгууллагаасаа хожуу анх удаа мөрдөж буй байгууллага болсон бол тухайлбал, хяналт тавигч байгууллага нь тайлагналын багцаа нэгтгэлийн зорилгоор аккруэл суурьт УСНББОУС-ын дагуу өмнө нь бэлтгэсэн боловч иж бүрэн санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлэн толилуулдаггүй байсан бол УСНББОУС 33-ын 129-р параграфыг мөрдөнө. Энэ нь зөвхөн хяналт тавигч байгууллагын тайлагналын багц УСНББОУС-ын хүлээн зөвшөөрөлтийн болон хэмжилтийн шаардлагуудтай бүрэн нийцсэн байх үед төдийгүй тайлангийн өдрийн дараах үйл явдлын шалгалт, тэтгэврийн зардлын

төвлөрсөн хуваарилалт гэх мэт асуудлуудын хувьд төвлөрсөн байдлаар тохируулга хийх үед мөн хамааралтай байж болно. Гэвч хяналтанд буй байгууллага нь хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд материаллаг бус боловч түүний өөрийн санхүүгийн тайлангийн хувьд материаллаг байх буруу илэрхийллийг хайхралгүй орхигдуулахыг УСНББОУС 33-ын 129-р параграфуар зөвшөөрдөггүй.

### **Толилуулга ба тодруулга**

ХЗУ90. Анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдөхдөө шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон заалтуудын давуу талыг ашигладаг тохиолдолд зарим мэдээллийг тодруулахыг УСНББОУС 33-ын 135-140-р параграфуар шаарддаг.

Үлгэрчлэн харуулвал:

#### **20Х2 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга**

#### **Тодруулга 48 – УСНББОУС 33-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудыг мөрдөх**

Х улсын секторын байгууллага нь 20Х1 оны 01 дүгээр сарын 01-нд аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөн бөгөөд газар, барилга, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хэмжихэд гурав хүртэлх жилийн чөлөөлөх хугацаа олгох ба төсөөлөн тооцсон өртөг ашиглахыг зөвшөөрдөг УСНББОУС 33-ын шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийг мөрдөх сонголт хийсэн.

Х улсын секторын байгууллага нь төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлох болон газар, барилга, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хэмжихдээ эдгээр чөлөөлөх нөхцлийн давуу талыг ашигласан. Шилжилтийн үеийн эдгээр чөлөөлөх нөхцлүүд болон заалтуудыг ашигласны үр дүнд тус байгууллага нь Х улсын секторын байгууллагын санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга ба аккруэл суурт УСНББОУС-д нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөх эдгээр шилжилтийн үеийн чөлөөлөлтийг ашигласан өдрөөр аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн талаархи бүрэн тодорхой мэдэгдлийг хийх боломжгүй болсон.

Шилжилтийн хугацаанд үнэн зөв толилуулга ба аккруэл суурт УСНББОУС-тай нийцэлтэд нөлөөлөх шилжилтийн үеийн өөр бусад чөлөөлөх нөхцлүүдийг аливаа бусад хөрөнгө, өр төлбөрт ашиглаагүй.

Энэхүү хянан үзэж буй хугацаанд Х улсын секторын байгууллага нь өөрийн хяналтанд буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг 20Х2 оны 6 дугаар сарын 30-нд тодорхойлсны дараа, уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн эхний үлдэгдлийг 1,200,000 ТН-ийн нэмэлт үнэ цэнээр дахин илэрхийлсэн.

Тухайн жилийн эцэст Х улсын секторын байгууллага нь газар, барилгын хувьд төсөөлөн тооцсон өртгийг хараахан тодорхойлоогүй байсан бөгөөд эдгээр хөрөнгийг өөрийн санхүүгийн тайланд хэмжиж тусгаагүй. 20Х2 оны 12 дугаар сарын 31-нд газар, барилгын эцсийн үлдэгдлийг 2,500,000 ТН-ээр тусгасан. Энэхүү үнэ цэнийг Х улсын секторын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тодорхойлсон.

Х улсын секторын байгууллага нь өөрийн газар, барилгыг хэмжих болон эдгээр хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг тодорхойлохдоо шилжилтийн үеийн гурван жилийн чөлөөлөх нөхцлийг ашиглахаар төлөвлөж байна.

Х улсын секторын байгууллага нь газрын үнэ цэнийг тогтоолгохын тулд үнэлгээчнийг томилон ажиллуулсан бөгөөд барилгын хэмжилтэнд зориулан загвар боловсруулсан. Газар, барилгын үнэлгээг тодорхойлох үйл явц нь түүний хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөний дагуу явагдаж байна.

АККРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

**УСНББОУС 33, Аккруэл Суурьт УСНББОУС-ыг Анх Удаа Мөрдөх-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудын товчоо**

ХЗУ91. Аккруэл суурьт бусад УСНББОУС-д тусгасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудыг дараах схемд товчоолоон харуулав.

УСНББОУС	Олгосон шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд							
	Үгүй	Тийм						
	Төсөөлөн тооцсон өртөг	Хүлээн зөвшөөрөлтөөс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Хэмжилтээс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтээс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Тодруулгаас 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Ажил гүйлгээ, үлдэгдэл, орлого, зардлыг устгаж цэвэрлэх	Бусад	
УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Толилуулаа					✓	3 жилийн чөлөөлөх хугацааг ашигладаг хэмжээгээр	• Зэрэглүүлэгдэх мэдээлэл толилуулахыг дэмжсэн	
УСНББОУС 2, Мөнгөн Гүйлгээний Тайлан	✓							
УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Бөрчлөлт ба Алдаа	✓							

АККУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө									<ul style="list-style-type: none"> <li>Хуримтлагдсан хөрвүүлэлтийн шаардлагыг мөрдөхөөс чөлөөлсөн</li> </ul>
УСНББОУС 5, Зээлийн Өртөө			√	Зөвшөөрөгд -сөн сонголтот аргыг нягтлан бодох бүртгэлийн бодлого гэж сонгосон үед					<ul style="list-style-type: none"> <li>Бенчмарк аргыг буцаах горимоор мөрдөхийг дэмжсэн</li> <li>Зөвшөөрөгдсөн сонголтот аргыг буцаах горимоор мөрдөх ёстой.</li> </ul>
УСНББОУС 9, Арилжааны Ажил Гүйлээний Орлого	√						√	Хөрөнгө, өр төлбөрийн хувьд 3 жилийн чөлөөлөх хугацааг ашигладаг хэмжээгээр	
УСНББОУС 10, Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал									<ul style="list-style-type: none"> <li>Ноцтой инфляцийн талаархи заалт хэт</li> </ul>



АКРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

УСНББОУС 11, Барилгын Гэрээ	√		√																
УСНББОУС 12, Бараа Материал			√				√			Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй бараа материал									
УСНББОУС13, Түрээс							√			Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй түрээсийн хөрөнгө, өр төлбөр									
УСНББОУС 14, Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал							√												

АККРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНББОУС 16, Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Ул Хөдлөх Хөрөнгө</p>		√	<p>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөө- гүй хөрөнгө оруулалтын зориулалт- ай үл хөдлөх хөрөнгө</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөр- сөн хөрөнгө оруулалт- ын зориулалт- тай үл хөдлөх хөрөнгө</p>					
<p>УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө</p>		√	<p>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөө- гүй үндсэн хөрөнгө</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөр- сөн үндсэн хөрөнгө</p>					
<p>УСНББОУС 18, Сегментийн Тайлагнал</p>	<p>√ 3 жилийн чөлөөлөх хугацааг ашиг- ладаг бол сегмен- тийн тайлан гаргахгүй</p>								

АККРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНББОУС 19, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө</p>			<p>✓</p> <p>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй хөрөнгөтэй зөвхөн холбоотой өр төлбөрийг тухайн зүйлийн буулгах, холдуулах ба газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын анхны тооцоололд оруулна</p>				
<p>УСНББОУС 20, Холбоотой Талуудын Тодруулаа</p>			<p>✓</p> <p>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй хөрөнгөтэй зөвхөн холбоотой өр төлбөрийг тухайн зүйлийн буулгах, холдуулах ба газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын анхны тооцоололд оруулна</p>				
<p>УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодөөгүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт</p>							<p>• Гүйцээх гориммоор мөрдөх</p>



АКРУЭЛ СУУРТ УСНБООС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНБООС 27, Хөдөө Аж Ахуй</p>			<p>✓</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн үйл ажиллагаа</p>	<p>✓</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн үйл ажиллагаа</p>			
<p>УСНБООС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулаа</p>								<ul style="list-style-type: none"> <li>• Тодорхой нөхцөлд өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг салган зааглахгүй байх заалт</li> </ul>	
<p>УСНБООС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт</p>	<p>✓</p>		<p>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй санхүүгийн хэрэглүүр</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хэрэглүүр</p>				<ul style="list-style-type: none"> <li>• Хөйжийн сонголт, үл хүлээн зөвшөөрөлт, хөйжийн нягтлан бодох бүртгэлийн талаархи заалт</li> <li>• Үнэ цэнийн бууралтын зарчмыг гүйцээх горимоор мөрдөх</li> </ul>	

АКРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга									<ul style="list-style-type: none"> <li>Эрсдлийн шинж төрөл ба хэмжээний талаар зэрэгцүүлэгдэх мэдээлэл толилуулахгүй</li> </ul>
УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө	√	Дотоод-доо бий болгос-ноос бусад биет бус хөрөнгө	√	Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй биет бус хөрөнгө	√	Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн биет бус хөрөнгө			<ul style="list-style-type: none"> <li>Дотооддоо бий болгосон ба өмнө нь зардлаар бүртгэсэн биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөх заалт</li> </ul>
УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл	√	Үйлчилгээний концессын хөрөнгө	√	Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр	√	Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн үйлчилгээний концессын хөрөнгө ба холбогдох өр төлбөр			<ul style="list-style-type: none"> <li>Холбогдох өр төлбөрийг хэрхэн хүлээн зөвшөөрөх талаархи заалт</li> </ul>

АКРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан</p>		√		<p>Бусад байгууллага дахь хувь оролцоог зохиж ёсоор ангилж, тодорхойлох</p>	√		<ul style="list-style-type: none"> <li>• Хяналт тавигч байгууллага ба хяналтанд буй байгууллага нь УСНББОУС-ыг өөр өөр хугацаанд мөрдсөн үеийн заалт</li> <li>• Нэгтгэсэн санхүүгийн тайлан байдлаар санхүүгийн тайланг бэлтгэхгүй байх чөлөөлөх нөхцөл</li> <li>• (Хөрөнгө оруулалтын байгууллагыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр үнэлэх ба уг өдөр бодит үнэ цэнээр хэмжих)</li> </ul>
<p>УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт</p>		√		<p>Бусад байгууллага дахь хувь оролцоог зохиж ёсоор ангилж, тодорхойлох</p>	√		<ul style="list-style-type: none"> <li>• Хяналт тавигч байгууллага ба хараат байгууллага нь УСНББОУС-ыг өөр өөр хугацаанд мөрдсөн үеийн заалт</li> <li>• Хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахгүй байх чөлөөлөх нөхцөл</li> </ul>

АККРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

						√	√	Бусад байгууллага дахь хувь оролцоог зохих ёсоор ангилж, тодорхойлох			√	<ul style="list-style-type: none"> <li>Хяналт тавигч байгууллага, хараат байгууллага, хамтын хяналтанд буй байгууллага нь УСНББОУС-ыг өөр өөр хугацаанд мөрдсөн үеийн заалт</li> <li>Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахгүй байх чөлөөлөх нөхцөл</li> </ul>
УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр												<ul style="list-style-type: none"> <li>Хувь тэнцүүлэн нэгтгэх аргыг ашиглан өмнө нь тайлагнасан хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг хэрхэн хэмжих талаархи заалт</li> </ul>
УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж						√	√	Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөгүй тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр ба	Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн тогтоосон тэтгэмж			<ul style="list-style-type: none"> <li>Анхны өр төлбөрийг хэрхэн тодорхойлох талаархи заалт</li> <li>Хуримтлагдсан актуар олз ба гарзыг салган тусгаарлахгүй байх заалт</li> </ul>



АКРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

		ажилтны урт хугацааны бусад тэтгэмж	болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хувьд			<ul style="list-style-type: none"> <li>Туршлагад үндэслсэн тохируулгын талаархи хэтийн мэдээлэл</li> </ul>
--	--	-------------------------------------------------	----------------------------------------------------------------------	--	--	----------------------------------------------------------------------------------------------------------------------------

## Хавсралт

**Аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, анх удаа мөрдөж буй байгууллага нь мөрдөх шаардлагатай ба/буюу мөрдөхөөр сонгож болох шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудын хоорондох ялгаатай талууд**

Шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудыг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь энэхүү УСНББОУС-ын нөхцлүүдийн хүрээнд хэрхэн мөрдөх шаардлагатай ба аккруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, анх удаа мөрдөж буй байгууллага нь мөрдөхөөр сонгож болох шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудыг энэ Хавсралтад доор товчоолон харуулав.

Сонгож болох эдгээр шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтууд нь УСНББОУС 33-ын 27-32-р параграфт тайлбарласанчлан, үнэн зөв толилуулга болон аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх уг анх удаа мөрдөж буй байгууллагын чадвар боломжид нөлөөлдөг тул үнэн зөв толилуулга ба аккруэл суурт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх чадвар боломжид нөлөөлдөг эсвэл нөлөөлдөггүй шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл, заалтуудыг энэ Хавсралтад ялган тодорхойлсон.

Шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл буюу заалт	Мөрдөх шаардлагатай шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд буюу заалтууд	Мөрдөж эсвэл сонгож болох шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд буюу заалтууд	
УСНББОУС 1 • Зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах	Үнэн зөв толилуулга ба аккруэл суурт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй	Үнэн зөв толилуулга ба аккруэл суурт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй	Үнэн зөв толилуулга ба аккруэл суурт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх
УСНББОУС 4 • УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх шилжилтийн үеийн хуримтлагдсан зөрүү		√	√

АКРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНББОУС 5</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зөвшөөрөгдсөн сонголтот арга, түүнчлэн чөлөөлтийн хугацааны давуу талыг ашигладаг</li> <li>• УСНББОУС-ыг мөрдсөн өдөр зөвшөөрөгдсөн сонголтот аргыг хэрэглэх – буцаах горимоор мөрдөх</li> <li>• УСНББОУС-ыг мөрдсөн өдөр бенчмарк аргыг хэрэглэх – Мөрдсөн өдрөөс өмнө болон дараа гарсан өртөг зардлын хувьд буцаах горимоор мөрдөх</li> </ul>		✓		✓
<p>УСНББОУС 9</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацааг мөрдсөнтэй холбоотойгоор орлогын хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтээс чөлөөлөх</li> </ul>				✓
<p>УСНББОУС 10</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хэт инфляцитай эдийн засаг нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр ноцтой хэт инфляцид өртөх эсэхийг тодорхойлох</li> <li>• УСНББОУС-ыг мөрдсөн өдөр нь тогтворжуулалтын өдөр эсвэл түүнээс хойш байвал хөрөнгө, өр төлбөрийг хэмжих</li> </ul>		✓		
<p>УСНББОУС 12</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх</li> </ul>		✓		✓

АКРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНББОУС 13</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөх хугацааг ашигладаг бол санхүүгийн түрээсийн өр төлбөр ба санхүүгийн түрээсийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй</li> <li>• Түрээсийн ангилал нь акруэл суурт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх нөхцөл байдалд үндэслэдэг</li> </ul>	<p>✓</p>		<p>✓</p>
<p>УСНББОУС 16</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх</li> </ul>			<p>✓</p>
<p>УСНББОУС 17</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх</li> </ul>			<p>✓</p>
<p>УСНББОУС 18</p> <ul style="list-style-type: none"> <li>• УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс хойш гурван жилийн дотор сегментийн тайланг бэлтгэхгүй</li> </ul>		<p>✓</p>	
<p>УСНББОУС 19</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөх хугацааг ашигладаг бол тухайн зүйлийн буулгах, холдуулах өртөг зардлын анхны тооцоололтой холбоотойгоор өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй ба хэмжихгүй</li> </ul>			<p>✓</p>

АКРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНББОУС 20</p> <ul style="list-style-type: none"> <li>Холбоотой талуудын харилцаа, холбоотой талуудын ажил гүйлгээ болон эрх бүхий албан тушаалтны талаархи мэдээллийг тодруулахгүй</li> </ul>			√
<p>УСНББОУС 21</p> <ul style="list-style-type: none"> <li>УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс, эсвэл хэрэв чөлөөлөлтийн хугацааг ашигладаг бол хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн өдрөөс эхлэн үнэ цэнийн бууралтын нөхцлийг гүйцээх горимоор мөрдөх</li> </ul>		√	
<p>УСНББОУС 26</p> <ul style="list-style-type: none"> <li>УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс, эсвэл хэрэв чөлөөлөлтийн хугацааг ашигладаг бол хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн өдрөөс эхлэн үнэ цэнийн бууралтын нөхцлийг гүйцээх горимоор мөрдөх</li> </ul>		√	
<p>УСНББОУС 27</p> <ul style="list-style-type: none"> <li>Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх</li> </ul>			√
<p>УСНББОУС 28</p> <ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн хэрэглүүр нь УСНББОУС-ыг мөрдсөн өдөр өр төлбөрийн болон цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэгтэй эсэхийг тодорхойлох</li> <li>УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр өр төлбөр байгаагүй бол нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг салган зааглах шаардлагагүй</li> </ul>		√	√

АКРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНББОУС 29</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгө, өр төлбөрийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх</li> </ul> <p><i>Ангилах</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• УСНББОУС-ыг мөрдсөн өдөр санхүүгийн хөрөнгө буюу өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах</li> </ul> <p><i>Үнэ цэнийн бууралт</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• УСНББОУС-ыг мөрдсөн өдөр үнэ цэнийн бууралтын нөхцлийг гүйцээх горимоор мөрдөх</li> </ul> <p><i>Үл хүлээн зөвшөөрөлт</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• УСНББОУС-ыг мөрдсөн өдөр үл хүлээн зөвшөөрөлтийн нөхцлийг гүйцээх горимоор мөрдөх</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>• Анх бүртгэх өдөр мэдээлэл нь бэлэн боломжтой байвал үл хүлээн зөвшөөрөлтийн нөхцлийг буцаах горимоор мөрдөх</li> </ul>	<p>✓</p> <p>✓</p> <p>✓</p> <p>✓</p>	<p>✓</p>	<p>✓</p>
<p><i>Хейжийн нягтлан бодох бүртгэл</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжих</li> <li>• Хойшуулсан бүх олз, гарзыг устгаж цэвэрлэх</li> <li>• УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг зөвхөн хангах хейжийг тусгах</li> <li>• УСНББОУС-ыг мөрдсөн өдөр хейжийн нягтлан бодох бүртгэлийн нөхцөл хангагдахгүй бол хейжийн ажил гүйлтээг зогсоох</li> </ul>	<p>✓</p> <p>✓</p> <p>✓</p> <p>✓</p>	<p>✓</p>	<p>✓</p>

АКРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНББОУС 30</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрсдлийн шинж төрөл ба хэмжээний талаархи мэдээллийг тодруулахгүй</li> </ul>		√			√
<p>УСНББОУС 31</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх</li> <li>• Дотооддоо бий болгосон бүх биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөх</li> </ul>	√				√
<p>УСНББОУС 32</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгө, өр төлбөрийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх</li> <li>• УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, эсвэл хэрэв чөлөөлөлтийн хугацааг ашигладаг бол хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн өдөр санхүүгийн өр төлбөрийн загвар ба эзэмшигчид эрх олгох загварын аль нэгээр өр төлбөрийг хэмжих</li> </ul>	√				√
<p>Хөрөнгө, өр төлбөрийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах</p>				√	
<p>Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийн хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах</p>				√	
<p>Хяналтанд буй байгууллага, хамтын хяналтанд буй байгууллага, хараат байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтын хувьд төсөөлөн тооцсон өртгийг ашиглах</p>				√	
<p>Шилжилтийн хугацаанд тохируулгын тайланг бэлтгэх</p>	√				

АКРҮЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНББОУС 35</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хяналтанд буй байгууллага дахь хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжихээс чөлөөлөх</li> <li>• Байгууллага хоорондын үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого, зардлыг устгаж цэвэрлэхгүй байх сонголт хийх</li> <li>• Хяналтанд буй байгууллага нь өөрийн хяналт тавигч байгууллагаас хожуу эсвэл эрт анх удаа мөрдөж буй байгууллага болох</li> </ul>	<p>✓</p>		<p>✓</p>
<ul style="list-style-type: none"> <li>• Хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилт, устгаж цэвэрлэх сонголтын хувьд гурван жилийн чөлөөлөх хугацааг ашигладаг бол санхүүгийн тайлангаа нэгтгэсэн санхүүгийн тайлан байдлаар толилуулахгүй байх</li> <li>• <i>(Хөрөнөө оруулалтын байгууллагыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр үнэлэх ба уг өдөр бодит үнэ цэнээр хэмжих)</i></li> </ul>	<p>✓</p>		<p>✓</p>
<p>УСНББОУС 36</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хараат байгууллага дахь хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжихээс чөлөөлөх</li> <li>• Хараат байгууллагын ашиг, алдагдал дахь хувь оролцоог устгаж цэвэрлэхгүй байх сонголт хийх</li> <li>• Хараат байгууллага нь өөрийн хяналт тавигч байгууллагаас хожуу эсвэл эрт анх удаа мөрдөж буй байгууллага болох</li> <li>• Хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилт, устгаж цэвэрлэх сонголтын хувьд гурван жилийн чөлөөлөх хугацааг ашигладаг бол санхүүгийн тайлангаа нэгтгэсэн санхүүгийн тайлан байдлаар толилуулахгүй байх</li> </ul>	<p>✓</p>		<p>✓</p> <p>✓</p> <p>✓</p>



АКРУЭЛ СУУРТ УСНББОУС-ЫГ АНХ УДАА МӨРДӨХ

<p>УСНББОУС 37</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хувь тэнцүүлэн нээгээх аргыг ашиглан өмнө нь тайлагнасан хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг хэмжих</li> </ul>	<p>√</p>		
<p>УСНББОУС 39</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд гурван жилийн чөлөөлөх хугацаа олгох ба хөрөнгө, өр төлбөрийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчлөх</li> <li>• Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хувьд анхны өр төлбөрийг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр эсвэл чөлөөлөх нөхцлийн хугацаа дууссан өдөр тодорхойлох</li> <li>• Нэмэгдэлт/бууралтыг УСНББОУС-ыг мөрдсөн өдөр эсвэл чөлөөлөх нөхцлийн хугацаа дууссан өдөр хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрөх</li> </ul>	<p>√</p>		<p>√</p>
	<p>√</p>		

ЭНЭ ХУУДСЫГ ЗОРИУД ХООСОН ОРХИСОН БОЛНО

## УСНББОУС 34–ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 27, *Тусдаа Санхүүгийн Тайлан*-гаас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 27-гоос авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 34-ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан-г 2015 оны 01 дүгээр сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 34-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 34-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
5	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
32А	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар

2015 оны 01 дүгээр сар

## УСНББОУС 34–ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### АГУУЛГА

---

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-5
Тодорхойлолт	6-10
Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэх	11-18
Тодруулга	19-23
Шилжилтийн нөхцөл	24-31
Хүчин төгөлдөр болох хугацаа	32-33
УСНББОУС 6 (2006 оны 12 дугаар сар)-гаас татгалзах ба орлуулах	34
Дүгнэлтийн үндэслэл	
НББОУС 27 (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-той харьцуулалт	

## ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*-г 1-34-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 34-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэхүү стандартын зорилго нь байгууллага тусдаа санхүүгийн тайлан гаргах тохиолдолд хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь түүний хөрөнгө оруулалтын хувьд нягтлан бодох бүртгэл ба тодруулгын шаардлагуудыг тодорхойлоход оршино.

## Цар хүрээ

2. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь тусдаа санхүүгийн тайлан толилуулах сонголт хийсэн эсвэл ингэж толилуулахыг хууль тогтоомжоор шаардсан тохиолдолд хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын тайлагналд энэхүү Стандартыг мөрдөнө.
3. Энэ Стандарт нь ямар байгууллага тусдаа санхүүгийн тайлан гаргахыг албан ёсоор тогтоохгүй. Харин байгууллага нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) -д нийцсэн тусдаа санхүүгийн тайлан гаргах тохиолдолд энэ Стандартыг мөрдөнө.
4. [Хассан]
5. [Хассан]

## Тодорхойлолт

6. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Нэгтгэсэн санхүүгийн тайлан гэдэг нь хяналт тавигч байгууллага болон түүний хяналтанд буй байгууллагуудын хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг эдийн засгийн нэг аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан мэтээр толилуулдаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайлан юм.

Тусдаа санхүүгийн тайлан гэдэг нь хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт* -ийн дагуу өртгөөр нь, эсвэл УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-д заасан өмчийн аргыг ашиглан тайлагнах сонголтыг энэхүү Стандартын шаардлагуудын дагуу хийж чадах тийм байгууллагын толилуулж буй санхүүгийн тайлан юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно. Дараах нэр томъёог УСНББОУС 35, *Нэгтгэсэн*

**Санхүүгийн Тайлан, УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт, УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр-т тодорхойлсон. Үүнд: хараат байгууллага, хяналт, хяналтанд буй байгууллага, хяналт тавигч байгууллага, эдийн засгийн нэгдмэл байгууллага, өмчийн арга, хөрөнгө оруулалтын байгууллага, хамтын хяналт, хамтын үйл ажиллагаа, хамтарсан үйлдвэр, хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч, мэдэгдэхүйц нөлөө.**

7. Тусдаа санхүүгийн тайлан нь хяналтанд буй байгууллагад хөрөнгө оруулалтгүй боловч хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэрт хөрөнгө оруулалттай бөгөөд тэдгээр хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг 9-10-р параграфт заасан нөхцлүүдээс бусад тохиолдолд УСНББОУС 36-гийн дагуу өмчийн арга ашиглан тайлагнах шаардлагатай хөрөнгө оруулагчийн санхүүгийн тайлан, эсвэл нэгтгэсэн санхүүгийн тайлангаас гадна нэмж толилуулдаг санхүүгийн тайлан юм.
8. Хяналтанд буй байгууллага болон хараат байгууллага байхгүй, эсвэл хамтарсан үйлдвэрт уг үйлдвэрийн хувь оруулагчийн оролцоогүй байгууллагын санхүүгийн тайлан нь тусдаа санхүүгийн тайлан биш юм.
9. УСНББОУС 35-ын 5-р параграфын дагуу нэгтгэл хийхээс, эсвэл УСНББОУС 36-гийн 23-р параграфын дагуу өмчийн арга ашиглахаас чөлөөлөгддөг байгууллага нь өөрийн цорын ганц санхүүгийн тайлан болгон тусдаа санхүүгийн тайланг толилуулж болно.
10. Толилуулж буй тухайн тайлант үед болон зэрэгцүүлэгдэх бүх өмнөх тайлант үеүдэд өөрийн хяналтанд буй бүх байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтыг УСНББОУС 35-ын 56-р параграфт заасанчлан, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шаардлагатай хөрөнгө оруулалтын байгууллага нь өөрийн цорын ганц санхүүгийн тайлан болгон тусдаа санхүүгийн тайланг толилуулж болно.

### **Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэх**

11. 12-р параграфт зааснаас бусад тохиолдолд тусдаа санхүүгийн тайланг холбогдох бүх УСНББОУС-ын дагуу гаргана.
12. Байгууллага нь тусдаа санхүүгийн тайлан гаргадаг тохиолдолд хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь адилтгах хөрөнгө оруулалтуудыг дараах хувилбаруудын аль нэгээр бүртгэж тайлагнана:
  - (а) Өртгөөр нь;
  - (б) УСНББОУС 29-ийн дагуу; эсвэл
  - (в) УСНББОУС 36-д заасны дагуу өмчийн аргыг ашиглана.
13. УСНББОУС 36-гийн 24-р параграфт заасанчлан, хэрэв байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан



бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийсэн бол тусдаа санхүүгийн тайландаа тэдгээр хөрөнгө оруулалтыг мөн энэхүү арга замаар тайлагнана.

14. УСНББОУС 35-ын 56-р параграфт заасанчлан, хэрэв хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шаардлагатай бол хяналтанд буй байгууллага дахь уг хөрөнгө оруулалтыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа мөн энэхүү арга замаар тайлагнана. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш, хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 35-ын 58-р параграфт заасанчлан, хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ба уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг нэгтгэх шаардлагатай бол тус байгууллага нь хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь тэрхүү хөрөнгө оруулалтыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа мөн энэхүү арга замаар тайлагнана.
15. Хяналт тавигч байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага байхаа больсон, эсвэл хөрөнгө оруулалтын байгууллага болсон тохиолдолд ийнхүү статус өөрчлөгдсөн өдрөөс эхлэн уг өөрчлөлтийг дараах байдлаар тайлагнана:
- (а) Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага байхаа больсон тохиолдолд хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтаа 12-р параграфын дагуу тайлагнана. Ийм статусын өөрчлөлтийн огноо нь төсөөлөн тооцсон худалдан авалтын өдөр байна. Хөрөнгө оруулалтыг 12-р параграфын дагуу тайлагнах үед тэрхүү төсөөлөн тооцсон худалдан авалтын өдрөөрх уг хяналтанд буй байгууллагын бодит үнэ цэнэ нь төсөөлөн тооцсон, шилжүүлэх төлбөрийн дүнг илэрхийлнэ.
- (б) Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага болсон тохиолдолд хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтаа УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тайлагнана. Хяналтанд буй байгууллагын өмнөх дансны үнэ ба хөрөнгө оруулагчийн статуст өөрчлөлт орсон уг өдрөөрх түүний бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд олз эсвэл гарз байдлаар хүлээн зөвшөөрнө. Тэдгээр хяналтанд буй байгууллагуудтай холбоотойгоор цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь шууд хүлээн зөвшөөрч байсан аливаа олз, гарзын хуримтлагдсан дүнг тухайн хөрөнгө оруулалтын байгууллага нь статуст өөрчлөлт орсон өдрөөр тэдгээр хяналтанд буй байгууллагуудаа данснаас хассан мэтээр бүртгэнэ.
16. Ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг авах уг байгууллагын эрхийг тодорхойлон тогтоосон тохиолдолд хяналтанд буй

байгууллага, хамтарсан үйлдвэр эсвэл хараат байгууллагаас авах ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг уг байгууллагын тусдаа санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь өмчийн арга ашиглах сонголт хийсэн, ингэснээр ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг тухайн хөрөнгө оруулалтын дансны үнийн бууралт байдлаар хүлээн зөвшөөрдөг байхаас бусад тохиолдолд ийм ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

17. Хяналт тавигч байгууллага нь дараах шалгуурыг хангах тийм байдлаар өөрийнхөө хяналт тавигч байгууллага байдлаар шинэ байгууллагыг үүсгэн байгуулснаар эдийн засгийн нэгдмэл байгууллагын бүтцийг дахин зохион байгуулж байгаа бөгөөд тухайн шинэ хяналт тавигч байгууллага нь анхны хяналт тавигч байгууллага дахь хөрөнгө оруулалтаа 12(a) параграфын дагуу өөрийн тусдаа санхүүгийн тайланд тайлагнадаг тохиолдолд тэрхүү шинэ хяналт тавигч байгууллага нь анхны хяналт тавигч байгууллагын тусдаа санхүүгийн тайланд тусгасан цэвэр хөрөнгө/өмчийн зүйлсэд хамаарах өөрийн хувь оролцооны дансны үнээр уг дахин зохион байгуулалтын өдрөөрх өртгийг хэмжиж тодорхойлно:
- (a) Шинэ хяналт тавигч байгууллага нь (i) анхны хяналт тавигч байгууллагын одоо байгаа өмчийн хэрэглүүрийн хариуд өмчийн хэрэглүүр гаргах, эсвэл (ii) шинэ хяналт тавигч байгууллага нь анхны хяналт тавигч байгууллагад хяналт тавих өмчлөлийн хувь оролцоотой болох үр дүн бүхий өөр бусад зарим арга механизмаар тэрхүү анхны хяналт тавигч байгууллагын хяналтыг олж авах;
  - (б) Шинэ болон анхны эдийн засгийн нэгдмэл байгууллагын хөрөнгө, өр төлбөр нь уг дахин зохион байгуулалтын өмнө ба дараа ижил байх;
  - (в) Дахин зохион байгуулалтын өмнөх анхны хяналт тавигч байгууллагын эзэд нь уг дахин зохион байгуулалтын өмнө ба дараа, анхны эдийн засгийн нэгдмэл байгууллага ба шинэ эдийн засгийн нэгдмэл байгууллагын цэвэр хөрөнгийн хувьд үнэмлэхүй дүнгээр болон хувийн жингээр ижил хувь оролцоотой байх.
18. Үүнтэй адилаар, хяналт тавигч байгууллага биш, байгууллага нь 17-р параграфт заасан шалгуурыг хангах тийм байдлаар өөрийн хяналт тавигч байгууллага болох шинэ байгууллагыг үүсгэн байгуулж болно. 17-р параграфт заасан шаардлагуудыг ийм дахин зохион байгуулалтын хувьд мөн нэгэн адил мөрдөнө. Энэ тохиолдолд “анхны хяналт тавигч байгууллага”, “анхны эдийн засгийн нэгдмэл байгууллага” гэдгийг “анхны байгууллага” гэж нэрлэнэ.

## Тодруулга

19. Байгууллага нь өөрийн тусдаа санхүүгийн тайландаа тодруулга хийж байгаа тохиолдолд холбогдох бүх УСНББОУС-ыг, үүн дотроо 20-23-р параграфт заасан шаардлагуудыг даган мөрдөнө.
20. Хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 35-ын 5-р параграфын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахгүй, харин тусдаа санхүүгийн тайлан бэлтгэх сонголт хийсэн тохиолдолд тэрхүү тусдаа санхүүгийн тайланд дараах зүйлсийг тодруулна:
- (а) Санхүүгийн тайлан нь тусдаа санхүүгийн тайлан болох энэ тухай; нэгтгэлээс чөлөөлөгдөх заалтыг ашигласан эсэх; УСНББОУС-д нийцсэн, нэгтгэсэн санхүүгийн тайланг олон нийтэд зориулан бэлтгэдэг уг байгууллагын нэр; тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланг олж авч болох хаяг.
  - (б) Хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь томоохон хөрөнгө оруулалтын жагсаалт, үүнд:
    - (i) Тэдгээр хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллагын нэр.
    - (ii) Тэдгээр хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллагын үйл ажиллагаа явуулж буй улс (хэрэв энэ нь хяналт тавигч байгууллагын улсаас өөр бол).
    - (iii) Тэдгээр байгууллагуудад эзэмшиж байгаа өмчлөлийн хувь оролцооны хэмжээ болон уг өмчлөлийн хувь оролцоог хэрхэн тодорхойлсон тухай тайлбар.
  - (в) Дээрх (б)-д жагсаасан хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг бүртгэхэд ашигласан аргын тайлбар тодорхойлолт.
21. Хяналт тавигч байгууллага болох (20-р параграфт заасан хяналт тавигч байгууллагаас бусад) хөрөнгө оруулалтын байгууллага нь 10-р параграфын дагуу өөрийн цорын ганц санхүүгийн тайлан болгон тусдаа санхүүгийн тайланг гаргадаг тохиолдолд энэ тухай тодруулга хийнэ. Уг хөрөнгө оруулалтын байгууллага нь УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-аар шаардсан, хөрөнгө оруулалтын байгууллагуудад хамаарах тодруулгуудыг мөн толилуулна.
22. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш, хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 35-ын 56-р параграфт заасанчлан, хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ба уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг нэгтгэх шаардлагатай бол энэ тухай тодруулга хийнэ. Тус байгууллага нь УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны*

**Тодруулга-аар шаардсан, хөрөнгө оруулалтын байгууллагуудад хамаарах тодруулгыг мөн толилуулна.**

23. Санхүүжигчийн хувьд хамтын хяналттай эсвэл мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг хяналт тавигч байгууллага (20-21 параграфт заасан хяналт тавигч байгууллагаас бусад) буюу хөрөнгө оруулагч нь тусдаа санхүүгийн тайлан бэлтгэдэг тохиолдолд уг хяналт тавигч байгууллага буюу хөрөнгө оруулагч нь санхүүгийн тайлангаа түүний хамаарах УСНББОУС 35, УСНББОУС 36 эсвэл УСНББОУС 37-гийн дагуу бэлтгэх эсэхээ тодорхойлно. Хяналт тавигч байгууллага буюу хөрөнгө оруулагч нь өөрийн тусдаа санхүүгийн тайландаа мөн дараах зүйлсийг тодруулна:
- (a) Тэрхүү тайлан нь тусдаа санхүүгийн тайлан бол энэ тухай, мөн хэрэв хууль тогтоомж болон эрх бүхий байгууллага шаардаагүй бол яагаад уг тайланг гаргах болсон шалтгаан;
  - (б) Хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь томоохон хөрөнгө оруулалтын жагсаалт, үүнд:
    - (i) Тэдгээр хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллагын нэр.
    - (ii) Тэдгээр хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллагын үйл ажиллагаа явуулж буй улс (хэрэв энэ нь хяналт тавигч байгууллагын улсаас өөр бол).
    - (iii) Тэдгээр байгууллагуудад эзэмшиж байгаа өмчлөлийн хувь оролцооны хэмжээ болон уг өмчлөлийн хувь оролцоог хэрхэн тодорхойлсон тухай тайлбар.
  - (в) Дээрх (б)-д жагсаасан хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг бүртгэхэд ашигласан аргын тайлбар тодорхойлолт.

### **Шилжилтийн нөхцөл**

24. Хяналтанд буй байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг өмнө нь өртгөөр хэмждэг байсан хөрөнгө оруулалтын байгууллага нь Стандартыг анх мөрдөх үедээ энэхүү Стандартын шаардлагууд байнга хүчин төгөлдөр үйлчилж байсан мэтээр тухайн хөрөнгө оруулалтыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит цэнээр хэмжинэ. Хөрөнгө оруулалтын байгууллага нь анх мөрдсөн өдрийн яг өмнөх тайлант жилд буцаах горимоор тохируулга хийх бөгөөд дараах зүйлсийн хоорондох аливаа зөрүүний хувьд тэрхүү яг өмнөх тайлант жилийн эхэн дэх хуримтлагдсан ашиг, алдагдлыг тохируулна:
- (a) Хөрөнгө оруулалтын уг өмнөх тайлант үеийн дансны үнэ; ба
  - (б) Хяналтанд буй байгууллага дахь тухайн хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ.

25. Хяналтанд буй байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг өмнө нь цэвэр хөрөнгө/өмчөөр шууд дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг байсан хөрөнгө оруулалтын байгууллага нь Стандартыг анх мөрдсөн үед тухайн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр нь үргэлжлүүлэн хэмжинэ. Цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь хүлээн зөвшөөрч байсан бодит үнэ цэнийн аливаа тохируулгын хуримтлагдсан дүнг Стандартыг анх мөрдсөн өдрийн яг өмнөх тайлант жилийн эхэн дэх хуримтлагдсан ашиг, алдагдалд шилжүүлнэ.
26. УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихээр өмнө нь сонгож шийдсэн, хяналтанд буй байгууллага дахь хувь оролцооны өмнөх тайлагналын хувьд 12-р параграфтаар зөвшөөрсний дагуу хөрөнгө оруулалтын байгууллага нь Стандартыг анх мөрдөх үедээ тохируулга хийхгүй.
27. Хөрөнгө оруулалтын байгууллага нь хөрөнгө оруулагчид буюу удирдлагад өмнө нь тайлагнаж байсан бодит үнэ цэнийн дүнг ашиглана.
28. Хэрэв хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтыг 24-27-р параграфуудын дагуу хэмжих практик боломжгүй бол (УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-нд тодорхойлсны дагуу) хөрөнгө оруулалтын байгууллага нь 24-27-р параграфуудыг мөрдөх практик боломжтой хамгийн эхний тайлант үеийн эхнээс, магадгүй тухайн тайлант үеэс энэхүү Стандартын шаардлагуудыг даган мөрдөнө. Энэ параграфыг мөрдөх практик боломжтой хамгийн эхний тайлант үеийн эхлэл нь тухайн тайлант үе байхаас бусад тохиолдолд хөрөнгө оруулагч нь энэхүү анхны мөрдөлтийн яг өмнөх тайлант жилд буцаах горимоор тохируулга хийнэ. Хөрөнгө оруулалтын байгууллага өөрийн хяналтанд буй байгууллагынхаа бодит үнэ цэнийг хэмжих практик боломжтой өдөр нь яг өмнөх тайлант үеийн эхнээс урд өмнө байх тохиолдолд уг хөрөнгө оруулагч нь дараах зүйлсийн хоорондох аливаа зөрүүний хувьд тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэн дэх цэвэр хөрөнгө/өмчийг тохируулна:
- (а) Хөрөнгө оруулалтын уг өмнөх тайлант үеийн дансны үнэ; ба
  - (б) Хяналтанд буй байгууллага дахь тухайн хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ.
- Хэрэв энэ параграфыг мөрдөх практик боломжтой хамгийн эхний тайлант үе нь тухайн тайлант үе бол цэвэр хөрөнгө/өмчид хийх тохируулгыг тухайн тайлант үеийн эхэнд хүлээн зөвшөөрнө.
29. Хэрэв хөрөнгө оруулалтын байгууллага нь энэ Стандартыг анх мөрдөхөөс өмнө хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтаа данснаас хассан эсвэл түүн дэх хяналтаа алдсан бол тухайн хөрөнгө оруулалтын байгууллага нь уг хөрөнгө оруулалтын өмнөх үеийн тайлагналын хувьд тохируулга хийх шаардлагагүй юм.

30. Стандартыг анх мөрдсөн өдөр, өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш боловч УСНББОУС 35-ын 56-р параграфт заасанчлан, хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ба уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг нэгтгэх шаардлагатай, хяналт тавигч байгууллага нь тэрхүү хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайландаа тайлагнахдаа 24-29-р параграфт заасан, шилжилтийн нөхцлүүдийг ашиглана.
31. Хамтын үйл ажиллагаанд оруулсан түүний хувь оролцоог уг байгууллагын тусдаа санхүүгийн тайланд тусгах нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн талаархи шилжилтийн нөхцлүүдийг УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-т заасан.

### Хүчин төгөлдөр болох хугацаа

32. Байгууллага нь энэхүү Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 35, УСНББОУС 36, УСНББОУС 37, УСНББОУС 38-ыг мөрдөнө.
- 32A. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 4, 5-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
33. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

### УСНББОУС 6 (2006 оны 12 дугаар сар)-гаас татгалзах ба орлуулах

34. Энэ Стандартыг УСНББОУС 35-ын хамт гаргасан. Энэхүү хоёр Стандарт нь хамтдаа УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан* (2016 оны 12 дугаар сар)-г орлоно. УСНББОУС 34, УСНББОУС 35-ыг мөрдөх

## ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

эсвэл эдгээр Стандартууд хүчин төгөлдөр болох хугацааны аль түрүүнд болох өдөр хүртэл УСНББОУС 6 нь мөрдөгдсөн хэвээр байна.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 34-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Зорилго

ДҮ1. УСНББОУС 34-ийн дүгнэлтүүдэд хүрэхдээ УСНББОУС3-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. Энэ Стандарт нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУС3)-өөс гаргасан, НББОУС 27, *Тусдаа Санхүүгийн Тайлан* (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан ба үүн дотроо, 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүд)-д үндэслэсэн тул УСНББОУС 34 нь НББОУС 27 (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-гийн гол шаардлагуудаас гажсан эсвэл УСНББОУС3 нь ийм гажилтыг авч үзсэн зөвхөн тэдгээр талбаруудыг Дүгнэлтийн Үндэслэлд хамруулсан.

### Тойм

ДҮ2. УСНББОУС3 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны тайлагналыг зохицуулах УСНББОУС-уудыг шинэчлэх төслийн ажлыг 2012 онд эхэлсэн. *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцоо* гэж хамтад нь нэрлэх, Саналын Төсөл (СТ) 48-52-ыг УСНББОУС3 нь 2013 оны 10 дугаар сард гаргасан. СТ 48, *Тусдаа Санхүүгийн Тайлан* нь НББОУС 27, *Тусдаа Санхүүгийн Тайлан* (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-д үндэслэсэн бөгөөд УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан* дахь улсын секторын холбогдох засвар өөрчлөлтүүдийг авч үзсэн. 2015 оны 01 дүгээр сард УСНББОУС3 нь шинэ таван УСНББОУС-ыг, үүн дотроо УСНББОУС 34-ийг гаргасан. Эдгээр шинэ УСНББОУС-ууд нь УСНББОУС 6, УСНББОУС 7, *Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт*, УСНББОУС 8, *Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо*-г орлох юм.

### Тусдаа санхүүгийн тайланд өмчийн аргыг ашиглах

ДҮ3. Байгууллага нь хяналтанд буй байгууллага, хамтын хяналтанд буй байгууллага, хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа дараах байдлаар хэмжихийг УСНББОУС 6-гаар зөвшөөрдөг байсан:

- (а) Өмчийн арга ашиглан;
- (б) Өртгөөр; эсвэл
- (в) УСНББОУС 29-д заасанчлан, санхүүгийн хэрэглүүр байдлаар.

ДҮ4. Өмчийн арга ашиглах сонголтыг хассанаар НББОУС3 нь байгууллагын тусдаа санхүүгийн тайланд толилуулсан хөрөнгө оруулалтын хувьд хэмжилтийн сонголтуудыг 2003 онд хязгаарласан болохыг УСНББОУС3 тэмдэглэсэн. Ийм өөрчлөлтийг НББОУС3 хийх болсон шалтгаанд дараах зүйлс хамаарна гэж УСНББОУС3 тэмдэглэсэн:



## ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- (a) Тусдаа санхүүгийн тайланд гол анхаарах зүйл нь хөрөнгө оруулалт болохын хувьд тухайн хөрөнгийн гүйцэтгэл үр дүн юм. Өртөг ба бодит үнэ цэнэ нь үүнд хамааралтай мэдээллээр хангах юм; ба
- (б) Өмчийн арга нь хяналтанд буй байгууллага болон хараат байгууллагын ашиг, алдагдлын талаархи мэдээллээр хангадаг тохиолдолд тэрхүү мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайланд бэлэн боломжтой байна.

ДҮ5. СТ 48-ийг гаргах үедээ НББОУСЗ нь тусдаа санхүүгийн тайлан дахь өмчийн аргын хэрэглээг дахин харгалзан үзэх өөрийн санаа зорилгыг анхааруулан хэлсэн гэж УСНББОУСЗ мөн тэмдэглэсэн. Зарим улс орны компанийн тухай хууль нь тусдаа санхүүгийн тайланг толилуулах үедээ зарим хөрөнгө оруулалтыг хэмжихэд нягтлан бодох бүртгэлийн өмчийн аргыг ашиглахыг шаарддаг гэдгийг НББОУСЗ нь энэхүү асуудлыг дахин харгалзан үзэхээр шийдвэрлэхдээ мэдэгдсэн.

ДҮ6. УСНББОУСЗ нь дараах шалтгааны улмаас тусдаа санхүүгийн тайланд өмчийн арга ашиглахыг үргэлжлүүлэн зөвшөөрөхөөр шийдвэрлэсэн:

- (a) Өмчийн арга нь улсын секторын зарим хөрөнгө оруулалтыг тайлагнах сайн зохион байгуулагдсан арга юм. Улсын секторын байгууллагууд нь хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх маш олон нөхцөл байдалд өмчийн арга нь өртгийн арга ба бодит үнэ цэнийн аргаас илүү найдвартай<sup>1</sup>, ач холбогдолтой бөгөөд магадгүй арай бага өртөг зардалтай мэдээллээр хангадаг. Хувийн секторт нийтлэг тохиолддогийн адилаар хөрөнгө оруулалтын зорилгоор эзэмших биш, харин үйлчилгээ үзүүлэх боломжтой байхын тулд хөрөнгө оруулалтын байгууллагуудыг улсын секторт ихэвчлэн “хэрэглүүр” болгон ашигладаг. Өмчийн арга нь хөрөнгө оруулалтаас хамааран өмч болон үр дүнд цаг хугацааны явцад гарах хувьсан өөрчлөлтийг санхүүгийн тайланд өртөг зардал багатай бөгөөд хялбар ойлгомжтой байдлаар тусган харуулах боломж олгодог тул зарим тохиолдолд улсын секторын хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахад илүү сайн тохирдог байж болох юм.
- (б) Өртгийн аргыг хэрэглэхэд ихэвчлэн харьцангуй хялбар байдаг боловч хөрөнгө оруулалтыг тодорхой хугацаагаар эзэмших тохиолдолд өртгийн арга ашиглах нь хуучирсан ба хамаарал багатай мэдээлэл бий болгох үр дүнтэй бөгөөд ингэснээр хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байж болох юм.
- (в) Улсын секторын хувьд идэвхитэй зах зээлгүй болон бодит үнэ цэнийг нь шууд ажиглах боломжгүй тийм хөрөнгө оруулалтууд өндөр хувь хэмжээтэй байх магадлалтай юм. Ийм хөрөнгө оруулалтуудын үнэ

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

## ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

цэнийг тогтоохдоо УСНББОУС 29-д заасан, заавар удирдамжийг ашиглаж болох боловч энэ арга хандлага нь ерөнхийдөө суурь нөхцөл байдлыг үнэн зөв төлөөлөн илэрхийлэхгүй тийм мэдээллийг бий болгох үр дүнтэй байдаг гэж УСНББОУС3 үзсэн.

ДҮ7. СТ 48-д хариулт өгсөн ихэнх хүмүүс нь тусдаа санхүүгийн тайланд өмчийн арга ашиглахыг зөвшөөрсөн саналын төслийг дэмжсэн. Хариулт ирүүлсэн өөр бүлэг хүмүүс нь тусдаа санхүүгийн тайланд өмчийн арга ашиглахыг эргэн сэргээх НББОУС3-ийн саналаас хамааран энэхүү саналын төслийг мөн дэмжсэн. Өмчийн аргыг тусдаа санхүүгийн тайланд сонголт болгон эргэн сэргээсэн, *Тусдаа Санхүүгийн Тайлан дахь Өмчийн Арга (НББОУС 27-ийн Нэмэлт өөрчлөлт)*-ийг НББОУС3 нь 2014 оны 8 дугаар сард гаргасан. НББОУС3 нь энэхүү саналын төслийн хувьд хүлээн авсан дэмжлэг ба НББОУС 27-д өмчийн аргыг эргэн сэргээлтийг онцлон тэмдэглэсэн бөгөөд тусдаа санхүүгийн тайланд өмчийн аргыг үргэлжлүүлэн ашиглахыг зөвшөөрсөн.

### **Хөрөнгө оруулалтын байгууллагын тусдаа санхүүгийн тайлан**

ДҮ8. УСНББОУС 35-ыг боловсруулахдаа, УСНББОУС3 нь хөрөнгө оруулалтын байгууллага гэсэн ойлголт ухагдахууныг нэвтрүүлэх, түүнчлэн хөрөнгө оруулалтын байгууллага болох хяналт тавигч байгууллага нь өөрийн хяналтанд буй ихэнх байгууллагууд дахь хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийг шаардах шийдвэр гаргасан. Иймээс УСНББОУС3 нь өөрийн хяналтанд буй байгууллагуудад оруулсан хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайландаа ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийг хөрөнгө оруулалтын байгууллагаас шаардахаар шийдвэрлэсэн. Өөрийн цорын ганц санхүүгийн тайлан байдлаар тусдаа санхүүгийн тайланг бэлтгэж буй хөрөнгө оруулалтын байгууллага нь хяналтанд буй байгууллагууд дахь хувь оролцооны талаар УСНББОУС 38-д шаардсан тодруулгыг мөн хийх хэрэгтэй гэж УСНББОУС3 шийдвэрлэсэн.

ДҮ9. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш боловч хөрөнгө оруулалтын байгууллагын хяналт тавигч байгууллага нь дараах байдлаар нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахыг УСНББОУС3 нь түүнээс шаардахаар шийдвэрлэсэн. Үүнд: (i) хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих, ба (ii) уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг нэгтгэх. Ингэснээр хөрөнгө оруулалтын бус хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайландаа ижил арга замаар хэмжих хэрэгтэй гэж УСНББОУС3 нь шаардахаар шийдвэрлэсэн.

### **2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 34-т хийсэн хянан засварлалт**

ДҮ10. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит

## ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (a) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **НББОУС 27 (2011 ОНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН)-ТОЙ ХАРЬЦУУЛАЛТ**

УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*-г НББОУС 27, *Тусдаа Санхүүгийн Тайлан* (2011 онд Нэмэлт өөрчлөлт оруулсан, үүн дотроо 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан)-гаас үндсэндээ бэлтгэсэн. Энэ Стандартыг гаргах үед УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагуудад СТОУС 9, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийн мөрдөгдөх боломжтой байдлыг харгалзан үзээгүй байсан. Иймээс уг суурь үндэслэл болох НББОУСЗ-ийн стандарт дахь СТОУС 9 гэсэн хэллэгийг санхүүгийн хэрэглүүрүүдийг зохицуулж байсан УСНББОУС-уудын хэллэгээр орлуулсан болно.

УСНББОУС 34 ба НББОУС 27 (2011 онд Нэмэлт өөрчлөлт оруулсан)-гийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 34 нь зарим тохиолдолд НББОУС 27 (2011 онд Нэмэлт өөрчлөлт оруулсан)-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 34 дэх “цэвэр хөрөнгө/өмч”, “эдийн засгийн нэгдмэл байгууллага”, “хяналт тавигч байгууллага”, “хяналтанд буй байгууллага”, “орлого” /revenue/ гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 27 (2011 онд Нэмэлт өөрчлөлт оруулсан) дахь адилтгах нэр томъёо нь “өмч”, “групп”, “толгой компани”, “охин компани”, “орлого” /income/ юм.
- УСНББОУС 34 нь өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш боловч хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагад хөрөнгө оруулалттай хяналт тавигч байгууллагад хамаарах тусгай шаардлагуудыг агуулсан байдаг. НББОУС 27 (2011 онд Нэмэлт өөрчлөлт оруулсан) нь ийм хөрөнгө оруулалтыг нэгтгэхийг шаарддаг тул тухайн хяналт тавигч аж ахуйн нэгжид хамаарах өөр шаардлагуудыг тусгайлан заагаагүй.

## УСНББОУС 35–НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) 10, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-гаас үндсэндээ бэлтгэсэн болно. СТОУС 10-аас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 35-НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-г 2015 оны 01 дүгээр сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 35-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл* (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж* (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал* (2016 оны 4 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 35-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
4	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
8	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
11	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
12	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
13	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
40	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
52	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
55A	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
56	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
57	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
63	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

79А	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
79Б	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
79В	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
79Г	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар

**УСНББОУС 35–НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1-2
Цар хүрээ	3-13
Улсын секторын нэгдэл	4
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн толилуулга	5-10
Улсын Үйлдвэрийн Газар	11-13
Тодорхойлолт	14-17
Заавал биелүүлэх хэлцэл	15
Эдийн засгийн нэгдмэл байгууллага	16-17
Хяналт	18-37
Бүрэн эрх	23-29
Өгөөж	30-34
Бүрэн эрх ба өгөөжийн хоорондох холбоо	35-37
Нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд	38-55
Нэгтгэлийн горим	40
Нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлого	41
Хэмжилт	42
Боломжит саналын эрх	43-45
Тайлагналын өдөр	46
Хяналтын бус хувь оролцоо	47-51
Хяналтаа алдах	52-55
Хөрөнгө оруулалтын байгууллага: Бодит үнэ цэнийн шаардлага	56-64
Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага эсэхийг тодорхойлох	59-60
Шүүн тунгаалт ба таамаглал	61-62
Хөрөнгө оруулалтын байгууллагын статусын өөрчлөлтийг тайлагнах	63-64
Шилжилтийн нөхцөл	65-78
Хүчин төгөлдөр болох хугацаа	79-80
УСНББОУС 6 (2006 оны 12 дугаар сар)-гаас татгалзах ба орлуулах	81
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
Үлгэрчилсэн жишээ	
СТОУС 10-тай харьцуулалт	



## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-г 1-81-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 35-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь байгууллага нэг буюу хэд хэдэн өөр байгууллагуудыг хянадаг тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх ба толилуулах зарчмуудыг тогтооход оршино.
2. 1-р параграфт дурдсан зорилгыг биелүүлэхийн тулд энэ Стандарт нь:
  - (а) Нэг буюу хэд хэдэн өөр байгууллагууд (хяналтанд буй байгууллагууд)-ыг хянадаг байгууллага (хяналт тавигч байгууллага) нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулахыг шаарддаг;
  - (б) Хяналтын зарчмыг тодорхойлсон бөгөөд хяналтыг ийм нэгтгэлийн суурь үндэслэл гэж тогтоосон;
  - (в) Нэг байгууллага нь нөгөө байгууллагыг хянадаг, иймээс уг байгууллагыг нэгтгэх ёстой эсэхийг тогтоохын тулд хяналтын зарчмыг хэрхэн мөрдөхийг заасан;
  - (г) Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг тогтоосон; ба
  - (д) Хөрөнгө оруулалтын байгууллагыг тодорхойлсон бөгөөд тухайн тодорхой хяналтанд буй байгууллагуудыг хөрөнгө оруулалтын байгууллагад нэгтгэхгүй, гажих нөхцлийг заасан.

## Цар хүрээ

3. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахдаа энэхүү Стандартыг мөрдөнө.**

## Улсын секторын нэгдэл

4. Энэ Стандарт нь улсын секторын нэгдлийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд ба нэгдэлд тэдгээрийн үзүүлэх үр нөлөө, үүн дотроо улсын секторын нэгдлээс бий болсон гүүдвилийг авч үздэггүй (УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийг үзнэ үү).

## Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн толилуулга

5. **Хяналт тавигч байгууллага болох аливаа байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулна. Дараах бүх нөхцлийг хангаж байвал нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулах шаардлагагүй хяналт тавигч байгууллагаас бусад, бүх байгууллагууд нь энэ Стандартыг дагаж мөрдөнө:**
  - (а) Энэ нь өөрөө өөр байгууллагын хяналтанд буй байгууллага бөгөөд түүний хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг тухайн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар хангадаг, харин бүрэн бус эзэмшлийн хяналтанд буй

байгууллага байх тохиолдолд түүний бусад бүх эздэд, үүн дотроо саналын эрхгүй эзэмшигчдэд уг байгууллага нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулахгүй гэдгийг мэдэгдсэн бөгөөд тэд эсэргүүцээгүй;

- (б) Түүний өрийн буюу өмчийн хэрэглүүрийг хөрөнгийн зах зээл (дотоодын буюу гадаадын хөрөнгийн бирж, орон нутгийн болон бүс нутгийн албан бус зах зээл)-д арилжаалдаггүй;
  - (в) Байгууллага нь хөрөнгийн зах зээлд ямар нэг санхүүгийн хэрэглүүр гаргах зорилгоор өөрийн санхүүгийн тайланг үнэт цаасны хороо буюу бусад зохицуулагч байгууллагад танилцуулаагүй, мөн ингэж танилцуулахаар бэлтгээгүй; ба
  - (г) Түүний хамгийн эцсийн эсвэл завсрын аль нэг хяналт тавигч байгууллага нь олон нийт ашиглах боломжтой ба Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-уудад нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэдэг, тэрхүү санхүүгийн тайландаа хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэдэг буюу энэ Стандартын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр нь хэмждэг.
6. УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг мөрддөг ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр болон ажилтны бусад урт хугацаат тэтгэмжийн хөтөлбөрт энэ Стандартыг даган мөрдөхгүй.
7. **Хөрөнгө оруулалтын байгууллага болох хяналт тавигч байгууллага нь энэ Стандартын 56-р параграфт зааснаар өөрийн хяналтанд буй бүх байгууллагуудыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шаардлагатай бол уг хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулахгүй.**
8. Хяналтанд буй байгууллагын үйл ажиллагаа нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх бусад байгууллагуудтай ижил төсөөгүй тул уг хяналтанд буй байгууллагыг нэгтгэлээс, тухайлбал, улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудыг төсвийн секторын байгууллагуудтай нэгтгэх нэгтгэлээс хасахгүй. Ийм хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэх ба тэдгээр хяналтанд буй байгууллагуудын янз бүрийн үйл ажиллагааны талаархи нэмэлт мэдээллийг тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулснаар хамааралтай мэдээллээр хангадаг. Жишээлбэл; УСНББОУС 18, *Сегментийн Тайлагнал*-аар шаардсан тодруулгууд нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх янз бүрийн үйл ажиллагааны ач холбогдлыг тайлбарлахад тусалдаг.
9. Хяналтанд буй байгууллагын хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг түүний хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар хангадаггүй тохиолдолд 5-р параграфт заасан, нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхээс чөлөөлөх нөхцлийг мөрдөхгүй. Жишээлбэл; нийт засгийн газрын түвшний нэгтгэсэн санхүүгийн тайлан нь уг засгийн газрын гол сектор буюу үйл ажиллагааны хувьд хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангадаггүй байж болох юм. Олон улс орны хувьд, ийм хэрэглэгчдийн

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

мэдээллийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн санхүүгийн тайлагналын хуульчилсан шаардлагууд байдаг.

10. Энэ Стандартад заасан эдийн засгийн нэгдмэл байгууллагаас өөр бусад эдийн засгийн нэгдмэл байгууллагад хамаарах нэгтгэн нийлүүлсэн санхүүгийн тайлан бэлтгэхийг байгууллагаас (тухайлбал; хууль тогтоомжоор эсвэл гаднын хэрэглэгчид) шаардаж болох юм. Хэдийгээр ийм санхүүгийн тайлан нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй бөгөөд энэ Стандартын шаардлагуудад захирагдахгүй боловч байгууллага нь ийм нэгтгэн нийлүүлсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ энэ Стандартад заасан заавар удирдамжийг ашиглаж болно.

### Улсын Үйлдвэрийн Газар

11. [Хассан]
12. [Хассан]
13. [Хассан]

### Тодорхойлолт

14. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Өгөөж** гэдэг нь бусад байгууллагууд дахь оролцооноос байгууллагын олж авсан давуу тал юм. Өгөөж нь санхүүгийн буюу санхүүгийн бус байж болно. Бусад байгууллагууд дахь уг байгууллагын оролцооны бодит үр нөлөө нь эерэг эсвэл сөрөг төлөв байдалтай байж болно.

**Заавал биелүүлэх хэлцэл:** Энэ Стандартын зорилгын хувьд заавал биелүүлэх хэлцэл нь хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адил хууль ёсны хүчин төгөлдөр эрх, үүргийг бий болгодог хэлцэл юм. Энэ нь гэрээгээр үүссэн эрх болон бусад хууль ёсны эрхийг агуулсан байдаг.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлан** гэдэг нь хяналт тавигч байгууллага болон түүний хяналтанд буй байгууллагуудын хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг эдийн засгийн нэг нэгж байдлаар толилуулдаг тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайлан юм.

**Хяналт:** Нэг байгууллага нь нөгөө байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй бөгөөд уг нөгөө байгууллага дахь бүрэн эрхээрээ дамжуулан тэдгээр өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэх чадвар, боломжтой бол тухайн байгууллага нь нөгөө байгууллагыг хянаана.

**Хяналтанд буй байгууллага** гэдэг нь өөр байгууллагын хяналтанд байдаг байгууллага юм.

**Хяналт тавигч байгууллага** гэдэг нь нэг буюу хэд хэдэн байгууллагыг хянадаг байгууллага юм.

**Шийдвэр гаргагч** гэдэг нь шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, ба энэ нь үндсэн оролцогч эсвэл бусад талуудын төлөөлөн оролцогч байна.

**Эдийн засгийн нэгдмэл байгууллага** гэдэг нь хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй байгууллагууд юм.

**Хөрөнгө оруулалтын байгууллага** гэдэг нь дараах байгууллага юм:

- (а) Нэг буюу хэд хэдэн хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор тэдгээр хөрөнгө оруулагчдаас мөнгө, санхүүжилт авдаг;
- (б) Гагцхүү капиталын үнийн өсөлт, хөрөнгө оруулалтын орлого эсвэл энэ хоёрын аль алианаас ашиг олох зорилгоор уг мөнгө сангаар хөрөнгө оруулалт хийх зорилготой байдаг; ба
- (в) Өөрийн бараг бүх хөрөнгө оруулалтын үр дүнг бодит үнэ цэнийн сууриар үнэлж, хэмждэг.

**Хяналтын бус хувь оролцоо** гэдэг нь хяналт тавигч байгууллагад шууд болон шууд бусаар үл хамаарах хяналтанд буй байгууллага дахь цэвэр хөрөнгө/өмч юм.

**Бүрэн эрх** гэдэг нь өөр байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг олгодог эрхийг хэлнэ.

**Хамгаалалтын эрх** гэдэг нь тухайн эрхийг эзэмшиж буй талын хувь оролцоог хамгаалахад зориулагдсан эрх бөгөөд тэрхүү эрхийн хамаарах байгууллагын хувьд бүрэн эрхийг түүний эзэмшигчид олгодоггүй.

**Холбогдох үйл ажиллагаа:** Энэ Стандартын зорилгын хувьд, холбогдох үйл ажиллагаа гэдэг нь бусад байгууллага дахь оролцооноос тухайн байгууллагын хүлээн авах өгөөжийн шинж төрөл буюу дүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх уг боломжит хяналтанд буй байгууллагын үйл ажиллагаа юм.

**Цуцлах эрх** гэдэг нь шийдвэр гаргагчийн шийдвэр гаргах бүрэн эрхийг хасах эрх юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин

**нийтэлсэн болно. Дараах нэр томъёог УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт, УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр, УСНББОУС 38, Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга-д тодорхойлсон. Үүнд: хараат байгууллага, бусад байгууллага дахь хувь оролцоо, хамтарсан үйлдвэр, мэдэгдэхүйц нөлөө.**

### **Заавал биелүүлэх хэлцэл**

15. Заавал биелүүлэх хэлцлийг хэд хэдэн арга замаар нотлон харуулж болно. Заавал биелүүлэх хэлцлийг байнга биш боловч ихэвчлэн бичгээр үйлдэх бөгөөд талуудын хоорондох гэрээ эсвэл баримтжуулсан тохиролцоо хэлбэртэй байдаг. Хууль тогтоох эсвэл засаглах бүрэн эрх гэх мэт хуулиар тогтоосон механизм нь гэрээний тохиролцоотой адилаар хуулийн дагуу хүчин төгөлдөр болох хэлцлийг дангаараа эсвэл талуудын хоорондох гэрээтэй холбоотойгоор мөн үүсгэн бий болгодог.

### **Эдийн засгийн нэгдмэл байгууллага**

16. Хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй аливаа байгууллагуудаас бүрдэх байгууллагуудын группыг санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлохын тулд энэ Стандартад эдийн засгийн нэгдмэл байгууллага гэсэн нэр томъёог ашигласан. Эдийн засгийн нэгдмэл байгууллагыг илэрхийлэхийн тулд зарим үед захиргааны байгууллага, санхүүгийн байгууллага, нэгтгэсэн байгууллага, групп гэх мэт нэр томъёог ашигладаг. Эдийн засгийн нэгдмэл байгууллага нь нийгмийн бодлогын болон арилжааны аль аль зорилго бүхий байгууллагуудыг агуулсан байж болно.
17. Улс орны Үндсэн хуулийн зохицуулалтыг, ялангуяа засгийн газрын бүрэн эрхийг хязгаарлах болон хуваарилах арга зам, төрийн тогтолцоог хэрхэн бүрдүүлж, ажилуулж байгаа эсэхийг харгалзан үзсэнээр эдийн засгийн нэгдмэл байгууллагыг тодорхойлох шаардлагатай байдаг. Жишээлбэл; гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал, шүүх засаглалтай улс орны хувьд эдгээр нь нэгдсэн санхүүгийн тайланг шаардах хэрэглэгч бүхий эдийн засгийн нэгдмэл байгууллагыг хамтдаа бүрдүүлж болох юм. Ийм нэгтгэсэн санхүүгийн тайланг ихэвчлэн нийт засгийн газрын санхүүгийн тайлан гэж нэрлэдэг.

### **Хяналт (МЗУ2-МЗУ87-р параграфыг үзнэ үү)**

18. **Бусад байгууллага дахь оролцооныхоо шинж төрлөөс үл хамааран, тухайн байгууллага нь уг бусад байгууллагыг хянадаг эсэхээ үнэлснээр өөрөө хяналт тавигч байгууллага мөн эсэхийг тодорхойлно.**
19. **Байгууллага нь бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй бөгөөд уг бусад байгууллага дахь бүрэн**

**эрхээрээ дамжуулан тэдгээр өгөөжид нөлөө үзүүлэх чадвар, боломжтой бол тухайн байгууллага нь бусад байгууллагыг хянана.**

20. **Иймээс байгууллага нь дараах бүх шинжүүдтэй бол, зөвхөн тийм тохиолдолд уг байгууллага нь бусад байгууллагыг хянана:**
- (а) **Тухайн бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй (23-29-р параграфыг үзнэ үү);**
  - (б) **Тухайн бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй (30-34-р параграфыг үзнэ үү); ба**
  - (в) **Бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд уг бусад байгууллага дахь өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломжтой (35-37-р параграфыг үзнэ үү).**
21. **Байгууллага нь бусад байгууллагыг хянадаг эсэхээ үнэлэх үедээ бүх баримт материал болон нөхцөл байдлуудыг харгалзан үзнэ. Хэрэв баримт материал ба нөхцөл байдал нь 20-р параграфт жагсаан харуулсан хяналтын гурван элементийн нэг буюу хэд хэдэн элементэд өөрчлөлт орсон гэдгийг илэрхийлж байвал тухайн байгууллага нь уг бусад байгууллагыг хянадаг эсэхээ дахин үнэлж үзнэ (МЗУ82-МЗУ87-р параграфыг үзнэ үү).**
22. Хоёр буюу хэд хэдэн байгууллагууд нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэхийн тулд хамтран ажиллах шаардлагатай тохиолдолд тэдгээр нь бусад байгууллагыг хамтран хянадаг. Энэ тохиолдолд нэг байгууллага нь нөгөө байгууллагуудтай хамтрахгүйгээр үйл ажиллагааг удирдан чиглүүлж чадахгүй учраас аль нэг байгууллага нь уг бусад байгууллагыг дангаараа хянахгүй. Байгууллага бүр нь уг бусад байгууллага дахь өөрийн хувь оролцоог УСНББОУС 36, УСНББОУС 37 буюу санхүүгийн хэрэглүүрийг зохицуулдаг УСНББОУС-ууд (УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*, УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*, УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*) гэх мэт холбогдох УСНББОУС-уудын дагуу тайлагнана.

### **Бүрэн эрх**

23. Байгууллага нь холбогдох үйл ажиллагааг, өөрөөр хэлбэл, бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг түүнд олгодог эрхтэй тохиолдолд нөгөө байгууллагын хувьд бүрэн эрхтэй байна. Нөгөө байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг удирдан чиглүүлэх эрх нь уг нөгөө байгууллагын холбогдох үйл ажиллагааг тухайн байгууллага удирдан чиглүүлэх чадвар, боломжтой гэдгийг илэрхийлэх бөгөөд улсын сектор дахь бүрэн эрхийг батлан харуулах нийтлэг арга зам юм.

24. Бүрэн эрх нь эрхээс үүсдэг. Бусад байгууллагын хувьд бүрэн эрхийг хувьцаа гэх мэт өмчийн хэрэглүүрээр олгосон зөвхөн саналын эрхээр шууд олж авдаг бөгөөд тэдгээр хувьцааны өмчлөлийн саналын эрхийг харгалзан үзсэнээр үнэлж болох зарим тохиолдолд бүрэн эрхийн үнэлгээ нь энгийн хялбар байдаг. Гэвч улсын секторын байгууллагууд нь саналын эрхээс өөр эрхээр дамжуулан бусад байгууллагын бүрэн эрхийг ихэвчлэн олж авдаг. Байгууллага нь санхүүгийн хөрөнгө оруулалтын нотолгоо болох өмчийн хэрэглүүргүй боловч бусад байгууллагын хувьд бүрэн эрхийг бас олж авсан байж болно. Байгууллага нь заавал биелүүлэх хэлцлээр илэрхийлэгдэх эрхтэй байж болно. Эдгээр эрх нь тухайн байгууллагын хүртэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөөлөх тийм байдлаар хөрөнгийг захиран зарцуулах эсвэл өр төлбөрийг хариуцахыг бусад байгууллагаас шаардах бүрэн эрхийг уг байгууллагад олгож болох юм. Ийм эрх нь бусад байгууллагын хувьд бүрэн эрх үүсгэх үр дүнтэй эсэх үнэлгээ нь илүү нарийн цогц байх бөгөөд нэгээс олон хүчин зүйлсийг харгалзан үзэхийг шаардаж болох юм.
25. Байгууллага нь бусад байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа эсвэл тогтоосон чиг үүргийг уг бусад байгууллага гүйцэтгэх арга маягийн хувьд хариуцлага хүлээдэггүй боловч тэрхүү бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй байж болно. Улсын Их Хурал (УИХ)-аас томилогдсон байгууллага буюу албан тушаалтан нь засгийн газраас хараат бусаар өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг түүнд хууль тогтоомжоор олгож болох юм. Жишээлбэл; Ерөнхий аудитор ба Төрийн статистикч нь ихэвчлэн засгийн газраас хараат бусаар мэдээллийг олж авах, тайланг хэвлэн нийтлэх хууль ёсны бүрэн эрхтэй байдаг, шүүх нь ямагт шүүхийн хараат бус байдлын тухай ойлголт ухагдахууныг хэрэгжүүлэх тусгай бүрэн эрхтэй байдаг. УИХ-аас томилогдсон байгууллага нь түүний хүрээнд үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай ерөнхий үзүүлэлтүүдийг мөн хуулиар тогтоох ба ингэснээр уг байгууллага нь УИХ буюу адилтгах байгууллагаас тогтоосон зорилтуудтай нийцсэн байдлаар үйл ажиллагаагаа явуулахад хүргэж болох юм. Хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах хууль ёсны бүрэн эрхийн оршин байдал нь уг байгууллага үр өгөөж хүртэхийн тулд хууль ёсны бүрэн эрхтэй бусад байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн бодлогыг удирдан чиглүүлэх чадвар боломжтой байхад саад учруулахгүй. Жишээлбэл; мөнгөний бодлогын хувьд төв банк хараат бус байдалтай байх нь уг төв банкинд хяналт тавих боломжит байдалд саад учруулахгүй. Иймээс бүх баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай хэвээр байдаг.
26. Бусад байгууллагын хувьд эрхтэй байх нь энэ Стандартын зорилгод хамаарах бүрэн эрхийг заавал үүсгэх албагүй юм. Байгууллага нь зөвхөн дараах зүйлсийн оршин байдлын үр дүнд бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй болохгүй:
- (а) Зохицуулалтын хяналт (МЗУ12-р параграфыг үзнэ үү); эсвэл
  - (б) Эдийн засгийн хараат байдал (МЗУ41-МЗУ42-р параграфыг үзнэ үү).



27. Холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар боломж бүхий байгууллага нь уг удирдан чиглүүлэх эрхийг хараахан хэрэгжүүлээгүй байлаа ч гэсэн бүрэн эрхтэй байдаг. Хяналтын зорилгоор үнэлэгдэж буй бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг уг байгууллага удирдан чиглүүлж байгаа гэсэн нотолгоо нь байгууллага бүрэн эрхтэй эсэхийг тодорхойлоход туслах боловч хяналтын зорилгоор үнэлэгдэж буй тэрхүү бусад байгууллагын хувьд тухайн байгууллага бүрэн эрхтэй эсэхийг тодорхойлоход ийм нотолгоо нь дангаараа дүгнэлтийн шинжтэй болохгүй. Урьдчилан тодорхойлсон үйл ажиллагаатайгаар үүсгэн байгуулсан байгууллагын хувьд холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрхийг тэрхүү байгууллагыг үүсгэн байгуулсан үед хэрэгжүүлж болох юм.
28. Хоёр буюу хэд хэдэн байгууллага тус бүр нь өөр өөр холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх нэг талт чадвар боломжийг тэдэнд олгох одоогийн эрхүүдтэй бол уг бусад байгууллагаас хүртэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд хамгийн ихээр нөлөөлөх тийм үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар боломж бүхий байгууллага нь тэрхүү бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй байна.
29. Хэдийгээр бусад байгууллагууд нь холбогдох үйл ажиллагааны удирдан чиглүүлэлтэнд оролцох одоогийн чадвар боломжийг тэдэнд олгох одоогийн эрхүүдтэй тухайлбал, бусад нэг байгууллага нь мэдэгдэхүйц нөлөөтэй байлаа ч гэсэн тухайн байгууллага нь хяналтын хувьд үнэлэгдэж буй тэрхүү бусад байгууллагад бүрэн эрхтэй байж болно. Гэвч зөвхөн хамгаалалтын эрхийг эзэмшдэг байгууллага нь бусад байгууллагын хувьд бүрэн эрхгүй (МЗУ29-МЗУ31-р параграфыг үзнэ үү) ба иймээс уг бусад байгууллагыг хянахгүй.

### **Өгөөж**

30. Өөрийн оролцооноос хүртэхийг хүсэж буй өгөөж нь бусад байгууллагын үйл ажиллагааны үр дүнгээс хамааран хувьсан өөрчлөгдөх боломжтой тохиолдолд тухайн байгууллага нь хяналтын хувьд үнэлэгдэж буй уг бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх хувьсах өгөөжийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй байна. Байгууллага нь санхүүгийн буюу санхүүгийн бус эерэг өгөөжийн талаархи цаг хугацааны явц дахь хүлээлтийн үр дүнд тэдгээр бусад байгууллагуудад оролцоотой болдог. Гэвч хяналтын хувьд үнэлэгдэж буй бусад байгууллага дахь уг байгууллагын оролцооны бодит үр нөлөө нь тухайн тодорхой тайлант үед зөвхөн эерэг, зөвхөн сөрөг эсвэл эерэг ба сөрөг байж болно.
31. Хяналтын хувьд үнэлэгдэж буй бусад байгууллага дахь уг байгууллагын оролцооноос үүсэх өгөөж нь зөвхөн санхүүгийн, зөвхөн санхүүгийн бус эсвэл санхүүгийн ба санхүүгийн бус байж болно. Санхүүгийн өгөөж нь ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт гэх мэт хөрөнгө оруулалтын өгөөжийг агуулах бөгөөд үүнийг зарим үед “үр өгөөж” гэж нэрлэдэг. Санхүүгийн бус өгөөж нь санхүүгийн нэр томъёогоор хэмжигдэхгүй ховор хомс нөөцөөс үүсэх давуу талууд, түүнчлэн тухайн байгууллагын

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

үйлчилгээг хүлээн авагчдын шууд хүртсэн эдийн засгийн өгөөжийг агуулсан байдаг. Бусад байгууллагын үйл ажиллагаа нь тухайн байгууллагын зорилтуудтай яв цав нийцсэн (өөрөөр хэлбэл, тэдгээр нь уялдан тохирсон) ба өөрийн зорилтуудад хүрэхэд тэрхүү байгууллагад дэмжлэг үзүүлж байвал санхүүгийн бус өгөөж үүсдэг. Жишээлбэл; яв цав нийцсэн үйл ажиллагаа бүхий бусад байгууллага нь тухайн байгууллага үзүүлэхээр үүрэг хүлээх байсан тийм үйлчилгээгээр хангах тохиолдолд уг байгууллага нь өгөөж хүртэж болох юм. Яв цав нийцсэн үйл ажиллагааг сайн дураар гүйцэтгэж болно, эсвэл тухайн байгууллага нь тэдгээр үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр уг бусад байгууллагыг удирдан чиглүүлэх бүрэн эрхтэй байж болно. Хоёр байгууллага нь харилцан бие биенийхээ гүйцээлт болох зорилтуудтай (өөрөөр хэлбэл, нэг байгууллагын зорилт нь нөгөө байгууллагын зорилтыг нэмж дэлгэрүүлэх ба илүү бүрэн гүйцэд болгодог) тохиолдолд мөн санхүүгийн бус өгөөж үүсэж болно.

32. Байгууллага нь бусад байгууллага дахь өөрийн оролцооноос хүлээн авч болох санхүүгийн өгөөжийг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан:
- (а) Ногдол ашиг, өрийн үнэт цаасны хувьсах хүү, эдийн засгийн өгөөжийн бусад хуваарилалт;
  - (б) Бусад байгууллага дахь хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт эсвэл бууралтад өртөх эрсдэл;
  - (в) Санхүүгийн дэмжлэг, үүн дотроо томоохон төслүүдийн хувьд санхүүгийн дэмжлэг үзүүлэх хэлцлээс гарз хүлээх эрсдэл;
  - (г) Өртгийн хэмнэлт (жишээлбэл; байгууллага нь өөрийн үйл ажиллагаа буюу хөрөнгөтэй бусад байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгийг нэгтгэн нийлүүлснээр хэмжээний буюу өргөжилтийн хэмнэлт гаргадаг бол);
  - (д) Бусад байгууллагын татан буулгалтаар уг бусад байгууллагын хөрөнгө, өр төлбөр дэх үлдэх хувь оролцоо; ба
  - (е) Бусад байгууллагад ашиглагдах боломжгүй хувьсах өгөөжийн бусад эрсдэл.
33. Санхүүгийн бус өгөөжийн жишээнд дараах зүйлс хамаарна:
- (а) Бусад байгууллагын мэргэшсэн мэдлэгээс өгөөж хүртэх чадвар боломж;
  - (б) Байгууллага өөрийн зорилтуудад хүрэхэд туслах уг бусад байгууллагын гүйцэтгэж буй үйл ажиллагаанаас тухайн байгууллагад хамраарах үнэ цэнэ;
  - (в) Сайжруулсан үр дүн;
  - (г) Үр дүнгийн илүү үр ашигтай хүргэн нийлүүлэлт;
  - (д) Бараа, үйлчилгээний илүү үр ашигтай буюу үр дүнтэй үйлдвэрлэл ба хүргэлт;

- (е) Хөрөнгө ба холбогдох үйлчилгээг байж болох хугацаанаас эрт бэлэн болгох; ба
  - (ж) Үйлчилгээг байж болох хэмжээнээс илүү өндөр түвшний чанартай болгох.
34. Зөвхөн нэг байгууллага нь нөгөө байгууллагыг хянаж болох боловч нэгээс олон тал нь уг бусад байгууллагын өгөөжийг хуваалцаж болно. Жишээлбэл; хяналтын бус хувь оролцооны эзэмшигчид нь тухайн байгууллагын ашиг буюу бусад хуваарилалт гэх мэт санхүүгийн өгөөж, эсвэл хүссэн үр дүнтэй тэдгээр үйл ажиллагааны яв цав нийцэлт гэх мэт санхүүгийн бус өгөөжид оролцож болох юм.

### **Бүрэн эрх ба өгөөжийн хоорондох холбоо**

35. Байгууллага нь хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллагын хувьд зөвхөн бүрэн эрхтэй ба тухайн үнэлэгдэж буй байгууллага дахь оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн эрсдлийг хүлээдэг буюу өгөөжийг хүртэх эрхтэй төдийгүй хяналтын зорилгоор үнэлэгдэж буй тэрхүү байгууллагын оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөөлөхийн тулд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломжтой бол уг байгууллага нь нөгөө байгууллагыг хянана.
36. Яв цав нийцсэн зорилтууд оршин байх нь бусад байгууллагыг тухайн байгууллага хянадаг гэж дүгнэхэд дангаараа хангалтгүй юм. Хяналттай байхын тулд байгууллага нь өөрийн зорилтуудад хүрэхэд бусад байгууллагыг ажиллуулахаар түүнийг удирдан чиглүүлэх үүднээс уг хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллагын хувьд өөрийн бүрэн эрхийг бас ашиглах чадвар боломжтой байх шаардлагатай.
37. **Шийдвэр гаргах эрх бүхий байгууллага нь өөрөө үндсэн оролцогч эсвэл төлөөлөн оролцогч эсэхээ тодорхойлно. Шийдвэр гаргах эрх бүхий өөр байгууллага нь тухайн байгууллагын өмнөөс төлөөлөн оролцогчийн үүрэг гүйцэтгэж буй эсэхийг уг байгууллага бас тодорхойлно. Төлөөлөн оролцогч нь өөр нэг тал буюу талууд (үндсэн оролцогч)-ын өмнөөс, болон тэдний эрх ашгийн төлөө ажиллахаар үндсэндээ хөлслөгдсөн этгээд бөгөөд иймээс шийдвэр гаргах өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үедээ уг бусад байгууллагыг хянахгүй. Иймээс үндсэн оролцогчийн нэрийн өмнөөс биш боловч уг төлөөлөн оролцогч нь зарим үед үндсэн оролцогчийн бүрэн эрхийг эзэмших ба хэрэгжүүлж болох юм.**

### **Нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд**

38. **Хяналт тавигч байгууллага нь төсөөтэй нөхцөл байдал дахь ижил ажил гүйлгээ ба үйл явдлын хувьд нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлого баримталснаар нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэнэ.**

39. **Хяналтанд буй байгууллагын нэгтгэл нь бусад байгууллагын хяналтыг уг байгууллага олж авсан өдрөөс эхэлж, харин түүний хяналтыг алдсан үед дуусгавар болно.**

#### **Нэгтгэлийн горим**

40. Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь:
- (a) Хяналт тавигч байгууллагын хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг түүний хяналтанд буй байгууллагуудын эдгээр адилтгах зүйлстэй нэгтгэдэг.
  - (б) Хяналтанд буй байгууллага бүр дэх хяналт тавигч байгууллагын хөрөнгө оруулалтын дансны үнэ болон хяналтанд буй байгууллага бүрийн цэвэр хөрөнгө/өмч дэх уг хяналт тавигч байгууллагын хувь оролцоог харилцан суутгана (устгана) (аливаа холбогдох гүүдвилийг хэрхэн тайлагнахыг УСНББОУС 40-д тайлбарласан).
  - (в) Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээтэй холбоотой тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллага доторх хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг бүрэн устгаж цэвэрлэнэ (бараа материал, үндсэн хөрөнгө гэх мэт хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн уг эдийн засгийн нэгдмэл байгууллага доторх ажил гүйлгээнээс үүссэн ашиг, алдагдлыг бүрэн устгаж, цэвэрлэнэ). Эдийн засгийн нэгдмэл байгууллага доторх алдагдал нь нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шаардлагатай үнэ цэнийн бууралтыг илэрхийлж болох юм.

#### **Нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлого**

41. Хэрэв эдийн засгийн нэгдмэл байгууллагын гишүүн нь төсөөтэй нөхцөл байдал дахь ижил ажил гүйлгээ ба бусад үйл явдлын хувьд нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдснөөс өөр нягтлан бодох бүртгэлийн бодлогыг ашигладаг бол тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх үедээ уг гишүүний санхүүгийн тайланд зохих залруулгыг хийнэ.

#### **Хэмжилт**

42. Байгууллага нь хяналтанд буй байгууллагын хяналтыг олж авсан өдрөөс эхлэн хяналтгүй болох өдөр хүртэл тухайн хяналтанд буй байгууллагын орлого, зардлыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгана. Хяналтанд буй байгууллагын орлого, зардал нь тухайн худалдан авалтын өдрөөр нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн дүнд үндэслэдэг. Жишээлбэл; нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд тухайн худалдан авалтын өдрөөс хойш хүлээн зөвшөөрсөн элэгдлийн зардал нь нэгтгэсэн санхүүгийн тайланд тэрхүү худалдан авалтын өдрөөр хүлээн зөвшөөрсөн, холбогдох элэгдүүлэх хөрөнгийн бодит үнэ цэнэд үндэслэсэн байдаг.

**Боломжит саналын эрх**

43. Боломжит саналын эрх эсвэл боломжит саналын эрхийг агуулсан бусад үүсмэл хэрэглүүрүүд байгаа бол нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхдээ тухайн хяналт тавигч байгууллага болон хяналтын бус хувь оролцоонд хуваарилах ашиг, алдагдлын болон цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн хувь хэмжээ нь зөвхөн одоо оршин байгаа өмчлөлийн хувь оролцоонд үндэслэх бөгөөд 44-р параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд боломжит саналын эрх ба бусад үүсмэл хэрэглүүрүүдийн боломжит хэрэгжилт буюу хөрвүүлэлтийг харгалзан тусгахгүй.
44. Зарим тохиолдолд, өмчлөлийн хувь оролцоотой холбоотой өгөөжийг хүртэх эрхийг байгууллагад одоо олгох ажил гүйлгээний үр дүнд тухайн байгууллага нь мөн чанарын хувьд, одоогийн өмчлөлийн хувь оролцоотой байдаг. Ийм тохиолдолд, өгөөж хүртэх эрхийг тухайн байгууллагад одоо олгож буй тэдгээр боломжит саналын эрх болон бусад үүсмэл хэрэглүүрүүдийн эцсийн хэрэгжилтийг харгалзан үзсэнээр нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх үед хяналт тавигч байгууллага болон хяналтын бус хувь оролцоонд хуваарилах хувь хэмжээг тодорхойлдог.
45. Нэгтгэсэн хяналтанд буй байгууллагуудын хувь оролцооны хувьд УСНББОУС 28 ба УСНББОУС 29-ийг мөрдөхгүй. Боломжит саналын эрхийг агуулсан хэрэглүүр нь хяналтанд буй байгууллага дахь өмчлөлийн хувь оролцоотой холбоотой өгөөжийг хүртэх эрхийг мөн чанарын хувьд одоо олгодог тохиолдолд уг хэрэглүүр нь УСНББОУС 28 ба УСНББОУС 29-ийн шаардлагуудад хамаарахгүй. Бусад бүх тохиолдолд хяналтанд буй байгууллага дахь боломжит саналын эрхийг агуулсан хэрэглүүрийг УСНББОУС 28 ба УСНББОУС 29-ийн дагуу тайлагнана.

**Тайлагналын өдөр**

46. **Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан хяналт тавигч байгууллагын болон түүний хяналтанд буй байгууллагуудын санхүүгийн тайлангуудыг нэг ижил тайлангийн өдрөөр бэлтгэнэ. Хяналт тавигч байгууллагын тайлант үеийн эцэс нь хяналтанд буй байгууллагын тайлант үеийн эцсээс өөр бол уг хяналт тавигч байгууллага нь:**
- (a) **Хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайлангийн өдөртэй ижил өдрөөрх нэмэлт санхүүгийн мэдээллийг нэгтгэлийн зорилгоор олж авна; эсвэл**
  - (б) **Хяналтанд буй байгууллагын санхүүгийн тайлангийн өдөр ба нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдрийн хоорондох хугацаанд гарч тохиолдсон мэдэгдэхүйц ажил гүйлгээ буюу үйл явдлын үр нөлөөний хувьд залруулга хийсэн, уг хяналтанд буй байгууллагын хамгийн сүүлийн санхүүгийн тайланг ашиглана.**

**Хяналтын бус хувь оролцоо**

47. **Хяналт тавигч байгууллага нь хяналтын бус хувь оролцоог нэгтгэсэн санхүүгийн байдлын тайландаа цэвэр хөрөнгө/өмчийн хэсэгт, уг хяналт тавигч байгууллагын эздийн цэвэр хөрөнгө/өмчөөс тусад нь толилуулна.**
48. Хяналтанд буй байгууллага дахь хяналтаа тухайн хяналт тавигч байгууллага алдахад хүргэхгүй бөгөөд уг хяналтанд буй байгууллага дахь тэрхүү хяналт тавигч байгууллагын хувь оролцооны өөрчлөлт нь эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эзэдтэй хийсэн ажил гүйлгээ юм.
49. **Байгууллага нь ашиг, алдагдал түүнчлэн, цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн олз, гарз нэг бүрийг тухайн хяналт тавигч байгууллагын эзэд болон хяналтын бус хувь оролцоонд хамааруулан хуваарилна. Хэдийгээр хяналтын бус хувь оролцоо нь сөрөг үлдэгдэлтэй болох байсан ч гэсэн байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд хүлээн зөвшөөрсөн нийт дүнг тухайн хяналт тавигч байгууллагын эзэд болон хяналтын бус хувь оролцоонд мөн хамааруулан хуваарилна.**
50. **Хяналтанд буй байгууллага нь эргэлтэнд байгаа, хуримтлалтай, давуу эрхийн хувьцаатай бөгөөд түүнийг өмчийн хэрэглүүр гэж ангилсан ба хяналтын бус хувь оролцооны эзэмшигчид өмчилдөг бол хяналт тавигч байгууллага нь эдгээр хувьцаанд ногдол ашиг зарласан эсэхээс үл хамааран, тэдгээрийн ногдол ашгийн хувьд залруулга хийсний дараах ашиг, алдагдлаас өөрт хамаарах хэсгийг тооцоолно.**

*Хяналтын бус хувь оролцооны эзэмшиж буй хувь хэмжээн дэх өөрчлөлт*

51. **Хяналтын бус хувь оролцооны эзэмшиж буй цэвэр хөрөнгө/өмчийн хувь хэмжээ нь өөрчлөгдсөн бол байгууллага нь тухайн хяналтанд буй байгууллага дахь тэдгээрийн харгалзах хувь оролцооны өөрчлөлтийг тусгахын тулд хяналтын болон хяналтын бус хувь оролцооны дансны үнийг тохируулна. Байгууллага нь хяналтын бус хувь оролцоог тохируулсан дүн ба төлсөн (эсвэл хүлээн авсан) төлбөрийн бодит үнэ цэнэ хоорондох аливаа зөрүүг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх бөгөөд түүнийг тухайн хяналт тавигч байгууллагын эздэд хамааруулан хуваарилна.**

**Хяналтаа алдах**

52. **Хэрэв хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь хяналтаа алдвал уг хяналт тавигч байгууллага нь:**
  - (a) **Өмнө нь хяналтанд байсан байгууллагын хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаас хасаж, үл хүлээн зөвшөөрнө;**

- (б) Хяналтаа алдах үед өмнө нь хяналтанд байсан уг байгууллагад хадгалан үлдсэн аливаа хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрч, түүнийг болон тухайн хяналтанд байсан байгууллагаас авах эсвэл түүнд төлөх дүнг холбогдох УСНББОУС-уудын дагуу дараагийн тайлант үед тайлагнана. Тэрхүү үлдсэн хувь оролцоог 54(б)(iii) ба 55А параграфт заасны дагуу дахин хэмжинэ. Хяналтаа алдсан өдрөөр уг дахин хэмжсэн үнэ цэнийг УСНББОУС 29-ийн дагуу санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ, хэрэв хамааралтай бол тухайн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрөх үеийн өртөг гэж үзнэ.
- (в) Өмнөх хяналтын хувь оролцоонд хамаарах хяналтаа алдсантай холбоотой олз, гарзыг 54-55А параграфт тусгайлан заасны дагуу хүлээн зөвшөөрнө.

53. Хяналт тавигч байгууллага нь хоёр буюу хэд хэдэн үйлдэл (ажил гүйлгээ)-ийн үр дүнд хяналтанд буй байгууллага дахь хяналтаа алдаж болох юм. Гэвч зарим үед тэдгээр олон үйлдлийг нэг ажил гүйлгээ гэж тайлагнах хэрэгтэй гэдгийг нөхцөл байдал харуулж байдаг. Тэдгээр үйлдлүүдийг нэг ажил гүйлгээ гэж тайлагнах эсэхийг тодорхойлохдоо, хяналт тавигч байгууллага нь уг үйлдлүүдийн бүх нөхцөл, болзол болон тэдгээрийн эдийн засгийн үр нөлөөг харгалзан үзнэ. Хяналт тавигч байгууллага нь олон үйлдлийг нэг ажил гүйлгээ гэж тайлагнах хэрэгтэй гэдгийг дараах нэг буюу хэдэн нөхцөл илэрхийлнэ:

- (а) Тэдгээр нь нэг ижил хугацаанд эсвэл бие биенээсээ хамааралтай хийгддэг.;
- (б) Тэдгээр нь худалдаа арилжааны нэгдсэн нэг үр дүнд хүрэхээр зохион байгуулагдсан нэг ажил гүйлгээг бүрдүүлдэг.;
- (в) Нэг үйлдлийн гарч тохиолдолт нь наад зах нь өөр нэг үйлдлийн гарч тохиолдолтоос хамааралтай байдаг.
- (г) Нэг үйлдлийг дангаар нь авч үзэхэд эдийн засгийн хувьд зохисгүй боловч бусад үйлдлүүдийн хамт авч үзэхэд эдийн засгийн хувьд зохистой байдаг. Жишээлбэл; хөрөнгө оруулалтын нэг данснаас хасалтын хувьд үнийг зах зээлийн түвшнээс багаар тогтоосон ба уг хөрөнгө оруулалтын дараагийн данснаас хасалтын хувьд үнийг зах зээлийн түвшнээс өндрөөр тогтоож, буцаан нөхөгдөх байх.

54. Хэрэв хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь хяналтаа алдсан бол уг хяналт тавигч байгууллага нь:

- (а) Доорх зүйлсийг үл хүлээн зөвшөөрнө:
  - (i) Хяналтаа алдсан өдөр хяналтанд буй байгууллагын хөрөнгө (үүн дотроо, аливаа гүүдвил), өр төлбөрийг тэдгээрийн дансны үнээр; ба

- (ii) Хяналтаа алдсан өдөр уг өмнө нь хяналтанд байсан байгууллага дахь аливаа хяналтын бус хувь оролцооны дансны үнийг (үүн дотроо, тэдгээрт хамаарах цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн аливаа олз, гарзыг).
  - (б) Доорх зүйлсийг хүлээн зөвшөөрнө:
    - (i) Хяналтаа алдахад хүргэсэн ажил гүйлгээ, үйл явдал, нөхцөл байдлаас хэрэв байгаа бол хүлээн авсан аливаа төлбөрийн бодит үнэ цэнэ;
    - (ii) Хяналтаа алдахад хүргэсэн ажил гүйлгээ, үйл явдал буюу нөхцөл байдал нь эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эздэд олгосон уг хяналтанд буй байгууллагын хувьцааны хуваарилалтыг агуулдаг бол тэрхүү хуваарилалт; ба
    - (iii) Өмнө нь хяналтанд байсан байгууллагад хадгалан үлдсэн аливаа хөрөнгө оруулалтыг уг хяналтаа алдсан өдөр түүний бодит үнэ цэнээр.
  - (в) 55-р параграфт заасан үндэслэлээр тухайн хяналтанд буй байгууллагатай холбоотойгоор цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн дүнг хэрэв бусад УСНББОУС-уудаар шаардсан бол хуримтлагдсан ашиг, алдагдалд шууд шилжүүлнэ.
  - (г) Аливаа үр дүн болох зөрүүг уг хяналтанд буй байгууллагад хамааруулан ашиг, алдагдалд олз эсвэл гарз гэж хүлээн зөвшөөрнө.
55. Хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь хяналтаа алдсан тохиолдолд тухайн хяналт тавигч байгууллага нь тэрхүү хяналтанд буй байгууллагатай холбоотойгоор өмнө нь цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн бүх дүнг хэрэв холбогдох хөрөнгө, өр төлбөрийг шууд данснаас хассан бол шаардах байсантай ижил сууриар тайлагнана. Хэрэв өмнө нь цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийг тухайн хөрөнгийг данснаас хассанаар хуримтлагдсан ашиг, алдагдалд шууд шилжүүлэх байсан бол хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагын хяналтыг алдсан үедээ уг дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашиг, алдагдалд шууд шилжүүлнэ.
- 55А. Өмчийн арга ашиглан тайлагнадаг хараат байууллага буюу хамтарсан үйлдвэртэй холбоотой ажил гүйлгээний үр дүнд хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг өөртөө агуулаагүй тийм хяналтанд буй байгууллагын хяналтаа алдсан бол тухайн хяналт тавигч байгууллага нь уг олз, гарзыг 54-55-р параграфын дагуу тодорхойлно. Уг ажил гүйлгээнээс үүссэн олз, гарзыг тэрхүү хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх зөвхөн харилцан холбоогүй хөрөнгө оруулагчдын хувь оролцооны хэмжээгээр тухайн хяналт тавигч байгууллагын ашиг, алдагдалд



хүлээн зөвшөөрнө. Олзын үлдсэн хэсгийг тэрхүү хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж, устгана. Түүнчлэн, хэрэв хяналт тавигч байгууллага өмнө нь хяналтанд байсан байгууллагадаа хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг хадгалж үлдсэн бөгөөд уг хяналтанд байсан байгууллага нь одоо өмчийн арга ашиглан тайлагнах хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр болсон бол тухайн хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүссэн олз, гарзын хэсгийг тэрхүү шинэ хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх зөвхөн харилцан холбоогүй хөрөнгө оруулагчдын хувь оролцооны хэмжээгээр өөрийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Олзын үлдсэн хэсгийг уг өмнө нь хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж, устгана. Хэрэв хяналт тавигч байгууллага нь одоо УСНББОУС 29-ийн дагуу тайлагнах уг өмнө нь хяналтанд байсан байгууллагадаа хөрөнгө оруулалтын зарим хэсгийг хадгалж үлдсэн бол тэрхүү хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүссэн олз, гарзын хэсгийг тухайн хяналт тавигч байгууллагын ашиг, алдагдалд бүтэн дүнгээр нь хүлээн зөвшөөрнө.

### **Хөрөнгө оруулалтын байгууллага: Бодит үнэ цэнийн шаардлага**

56. 57-р параграфт зааснаас бусад тохиолдолд, хөрөнгө оруулалтын байгууллага нь өөр байгууллагын хяналтыг олж авах үедээ өөрийн хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэхгүй буюу УСНББОУС 40-ийг мөрдөхгүй. Харин үүний оронд, хөрөнгө оруулалтын байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтаа УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ.
57. Хэрэв хөрөнгө оруулалтын байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага биш хяналтанд буй байгууллагатай бөгөөд түүний үндсэн зорилго, үйл ажиллагаа нь тухайн хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай (МЗУ98-МЗУ100-р параграфыг үзнэ үү) холбоотойгоор үйлчилгээ үзүүлэх явдал бол уг хөрөнгө оруулалтын байгууллага нь 56-р параграфын шаардлагыг үл харгалзан тэрхүү хяналтанд буй байгууллагыг энэ Стандартын 38-55-р параграфын дагуу нэгтгэх бөгөөд ийм аливаа хяналтанд буй байгууллагын худалдан авалтын хувьд УСНББОУС 40-ийн шаардлагуудыг дагаж мөрдөнө.
58. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш боловч хөрөнгө оруулалтын байгууллагад хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулах бөгөөд үүнд: (i) уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь хөрөнгө оруулалтаа УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ, ба (ii) хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө ба өр төлбөр, орлого, зардлыг энэ Стандартын 38-55-р параграфын дагуу нэгтгэнэ.

**Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага эсэхийг тодорхойлох**

59. Байгууллага нь өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага эсэхийг үнэлэхдээ бүх баримт материал болон нөхцөл байдлуудыг, үүн дотроо өөрийн зорилго ба бүтцийг харгалзан үзнэ. Хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтын төлөв байдлуудыг МЗУ89-МЗУ106-р параграфт илүү дэлгэрэнгүй тайлбарласан. Хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг бүрдүүлдэг гурван элементийн нэг буюу хэд хэдэн элементэд өөрчлөлт орсон гэдгийг баримт материал болон нөхцөл байдал илэрхийлэн харуулж байвал хяналт тавигч байгууллага нь өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага эсэхээ дахин үнэлнэ.
60. Хөрөнгө оруулалтын байгууллага байхаа больсон эсвэл хөрөнгө оруулалтын байгууллага болсон хяналт тавигч байгууллага нь түүний статуст өөрчлөлт орсон өдрөөс эхлэн уг статусын өөрчлөлтийг гүйцээх горимоор тайлагнана (63-64-р параграфыг үзнэ үү).

**Шүүн тунгаалт ба таамаглал**

61. Дараах бүх шинж чанаруудтай байхаас бусад тохиолдолд өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага эсэхийг тодорхойлохдоо хийсэн гол шүүн тунгаалт ба таамаглалын хувьд УСНББОУС 38-ын 15-р параграфтаар шаардсан мэдээллийг уг хөрөнгө оруулалтын байгууллага нь тодруулна:
- (а) Тус байгууллага нь нэгээс олон хөрөнгө оруулагчдаас мөнгө, санг хүлээн авдаг (МЗУ89-МЗУ90-р параграфыг үзнэ үү);
  - (б) Тус байгууллага нь өмч буюу түүнтэй ижил төсөөтэй хувь оролцоо хэлбэрээр эзэмшдэг өмчлөлийн хувь оролцоотой (МЗУ91-МЗУ92-р параграфыг үзнэ үү); ба
  - (в) Тус байгууллага нь нэгээс олон хөрөнгө оруулалттай (МЗУ96-МЗУ97-р параграфыг үзнэ үү).
62. Эдгээр шинж чанаруудын аль нэг нь тухайн байгууллагад байхгүй бол түүнийг хөрөнгө оруулалтын байгууллага гэж ангилах шалгуур хангагдахгүй гэж заавал үзэх албагүй юм. Гэвч эдгээр бүх шинж чанарууд байхгүй байх нь тухайн байгууллага өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага эсэхийг тодорхойлохын тулд хийсэн гол шүүн тунгаалт ба таамаглалын талаархи мэдээллийг тодруулах шаардлагатай гэдгийг илэрхийлнэ.

**Хөрөнгө оруулалтын байгууллагын статусын өөрчлөлтийг тайлагнах**

63. Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага байхаа больсон тохиолдолд тухайн байгууллага нь 56-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр өмнө нь хэмжиж байсан аливаа хяналтанд буй байгууллагын хувьд УСНББОУС 40-ийг дагаж мөрдөнө. Ийм статусын өөрчлөлтийн өдөр нь төсөөлөн тооцсон худалдан авалтын өдөр байна. Төсөөлөн тооцсон худалдан авалтаас

үүссэн тохиролцоот худалдан авалтын аливаа гүүдвил буюу олзыг хэмжих тохиолдолд уг төсөөлөн тооцсон худалдан авалтын өдрөөрх хяналтанд буй байгууллагын бодит үнэ цэнэ нь тэрхүү шилжүүлсэн, төсөөлөн тооцсон төлбөрийг илэрхийлнэ. Статус өөрчлөгдсөн өдрөөс эхлэн бүх хяналтанд буй байгууллагуудыг энэ Стандартын 38-51-р параграфын дагуу нэгтгэнэ.

64. Хэрэв байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага болсон бол тухайн байгууллага нь 57-р параграфын дагуу нэгтгэсэн хэвээр байх хяналтанд буй байгууллагаас бусад, бүх хяналтанд буй байгууллагуудыг уг статусын өөрчлөлтийн өдрөөс эхлэн нэгтгэхээ болино. Хөрөнгө оруулалтын байгууллага нь тухайн өдөр тэдгээр хяналтанд буй байгууллагууд дахь хяналтаа алдсан мэтээр уг нэгтгэхээ больсон хяналтанд буй байгууллагуудад 52, 53-р параграфын шаардлагуудыг дагаж мөрдөнө.

### Шилжилтийн нөхцөл

65. 66-78-р параграфт тусгайлан зааснаас бусад тохиолдолд байгууллага нь энэ Стандартыг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу буцаах горимоор мөрдөнө.
66. Энэхүү Стандартыг анх мөрдөхөд УСНББОУС 3-ын 33-р параграфын шаардлагуудаас үл хамааран байгууллага нь энэ Стандартыг анх мөрдөх өдрийн яг өмнөх тайлант жилийн ('яг өмнөх тайлант үеийн') хувьд УСНББОУС 3-ын 33(е) параграфтаар шаардсан, зөвхөн тоон мэдээллийг толилуулах шаардлагатай байдаг. Байгууллага нь энэ мэдээллийг тухайн тайлант үед эсвэл өмнөх зэрэгцүүлэгдэх тайлант үеүдэд мөн толилуулж болох боловч заавал толилуулах шаардлагагүй юм.
67. Энэхүү Стандартын зорилгын хувьд, анх мөрдөх өдөр нь энэ Стандартыг анх удаа мөрдсөн тайлант жилийн эхэн байна.
68. Анх мөрдөх өдөр байгууллага нь дараах байгууллагуудын аль нэгэн дэх өөрийн оролцооны өмнөх тайлагналд залруулга хийх шаардлагагүй юм:
- (a) Уг өдөр УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан*-гийн дагуу нэгтгэх байсан, түүнчлэн энэ Стандартын дагуу нэгтгэсээр байгаа байгууллагууд; эсвэл
  - (b) Уг өдөр УСНББОУС 6-ийн дагуу нэгтгэхгүй байсан, түүнчлэн энэ Стандартын дагуу нэгтгэхгүй байгууллагууд.
69. Анх мөрдөх өдөр байгууллага нь тухайн өдөр оршин буй баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага эсэхийг үнэлнэ. Хэрэв анх мөрдөх өдөр байгууллага нь өөрийгөө хөрөнгө оруулалтын байгууллага гэж

дүгнэсэн бол 77-78-р параграфын биш, харин 70-73-р параграфын шаардлагуудыг даган мөрдөнө.

70. 57-р параграфын дагуу нэгтгэдэгээс бусад аливаа хяналтанд буй байгууллагын (үүнд 68-р параграф эсвэл 77-78-р параграфын аль тохиромжтойг мөрдөнө) хувьд, хөрөнгө оруулалтын байгууллага нь энэ Стандартын шаардлагууд байнга хүчин төгөлдөр үйлчилж байсан мэтээр аливаа хяналтанд буй байгууллага тус бүр дэх өөрийн хөрөнгө оруулалтыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ. Хөрөнгө оруулалтын байгууллага нь дараах хоёр дүнгийн хоорондох аливаа зөрүүний хувьд стандартыг анх мөрдөх өдрийн яг өмнөх тайлант жил болон уг яг өмнөх тайлант үеийн эхэн дэх цэвэр хөрөнгө/өмчийн аль алиныг буцаах горимоор залруулна:

(а) Уг хяналтанд буй байгууллагын өмнөх тайлант үеийн дансны үнэ; ба

(б) Хөрөнгө оруулалтын байгууллагын тухайн хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ.

Өмнө нь цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн байсан бодит үнэ цэнийн аливаа залруулгын хуримтлагдсан дүнг уг анх мөрдөх өдрийн яг өмнөх тайлант жилийн эхэнд дэх хуримтлагдсан ашиг, алдагдалд шилжүүлнэ.

71. Хөрөнгө оруулалтын байгууллага нь хөрөнгө оруулагчид болон удирдлагад өмнө нь тайлагнасан бодит үнэ цэнийн дүнг ашиглана.

72. Хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтыг 70-р параграфын дагуу хэмжих практик боломжгүй бол (УСНББОУС 3-д тодорхойлсон) хөрөнгө оруулалтын байгууллага нь 70-р параграфыг мөрдөх практик боломжтой хамгийн өмнөх тайлант үеийн, магадгүй тухайн тайлант үеийн эхнээс энэхүү Стандартын шаардлагуудыг мөрдөнө. Энэ параграфыг мөрдөх практик боломжтой хамгийн эхний тайлант үеийн эхлэл нь тухайн тайлант үе байхаас бусад тохиолдолд хөрөнгө оруулагч нь уг анх мөрдөх өдрийн яг өмнөх тайлант жилийг буцаах горимоор залруулна. Харин практик боломжтой хамгийн эхний тайлант үеийн эхлэл нь тухайн тайлант үе байх тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчид хийх залруулгыг уг тайлант үеийн эхэнд хүлээн зөвшөөрнө.

73. Хэрэв хөрөнгө оруулалтын байгууллага нь энэ Стандартыг анх мөрдөх өдрөөс өмнө, уг хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтаа данснаас хассан буюу хяналтаа алдсан бол тухайн хөрөнгө оруулалтын байгууллага нь тэрхүү хяналтанд буй байгууллагын өмнөх тайлагналд залруулга хийх шаардлагагүй юм.

74. УСНББОУС 6-гийн дагуу өмнө нь нэгтгэдэггүй байсан бусад байгууллагыг нэгтгэх хэрэгтэй гэж уг байгууллага нь анх мөрдсөн өдөр дүгнэсэн бол өмнө нэгтгэдэггүй байсан бусад байгууллагын хяналтыг тухайн байгууллага нь энэхүү Стандартын шаардлагуудын

дагуу олж авсан өдрөөс эхлэн нэгтгэдэг байсан мэтээр түүний хөрөнгө, өр төлбөр, хяналтын бус хувь оролцоог хэмжинэ. Тус байгууллага нь анх мөрдсөн өдрийн яг өмнөх тайлант жилийг буцаах горимоор залруулна. Хяналтыг олж авсан өдөр нь уг яг өмнөх тайлант үеийн эхлэлээс өмнө байх тохиолдолд тухайн байгууллага нь дараах дүнгүүдийн хоорондох аливаа зөрүүг тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэнд цэвэр хөрөнгө/өмчийн залруулга байдлаар хүлээн зөвшөөрнө:

- (a) Хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөр, хяналтын бус хувь оролцооны дүн; ба
- (б) Бусад байгууллага дахь тухайн байгууллагын оролцооны уг өмнөх дансны үнэ.

75. Хяналтанд буй байгууллагын хөрөнгө, өр төлбөр, хяналтын бус хувь оролцоог 74(а) эсвэл 74(б) параграфын дагуу хэмжих практик боломжгүй бол (УСНББОУС 3-д тодорхойлсон) тухайн байгууллага нь өмнө нэгтгэдэггүй байсан бусад байгууллагыг төсөөлөн тооцсон худалдан авалтын өдрөөс эхлэн нэгтгэдэг байсан мэтээр түүний хөрөнгө, өр төлбөр, хяналтын бус хувь оролцоог хэмжинэ. Тэрхүү төсөөлөн тооцсон худалдан авалтын өдөр нь энэ параграфыг мөрдөх практик боломжтой хамгийн өмнөх тайлант үеийн, магадгүй тухайн тайлант үеийн эхлэл байна.

76. Энэ параграфыг мөрдөх практик боломжтой хамгийн эхний тайлант үеийн эхлэл нь тухайн тайлант үе байхаас бусад тохиолдолд байгууллага нь уг анх мөрдөх өдрийн яг өмнөх тайлант жилийг буцаах горимоор залруулна. Харин төсөөлөн тооцсон худалдан авалтын өдөр нь уг яг өмнөх тайлант үеийн эхлэлээс өмнө байх тохиолдолд байгууллага нь дараах дүнгүүдийн хоорондох аливаа зөрүүг тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэнд цэвэр хөрөнгө/өмчийн залруулга байдлаар хүлээн зөвшөөрнө:

- (a) Хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөр, хяналтын бус хувь оролцооны дүн; ба
- (б) Бусад байгууллага дахь тухайн байгууллагын оролцооны уг өмнөх дансны үнэ.

Энэ параграфыг мөрдөх практик боломжтой хамгийн эхний тайлант үе нь тухайн тайлант үе байх тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчид хийх залруулгыг уг тайлант үеийн эхэнд хүлээн зөвшөөрнө.

77. УСНББОУС 6-гийн дагуу өмнө нь нэгтгэдэг байсан бусад байгууллагыг цаашид нэгтгэхгүй гэж хяналт тавигч байгууллага нь уг анх мөрдөх өдөр дүгнэсэн бол тухайн хяналт тавигч байгууллага нь бусад байгууллагад оролцоотой болсон эсвэл хяналтаа алдсан үеэс энэ Стандартын ийм шаардлага хүчин төгөлдөр болсон бол хэмжих байсан дүнгээр тэрхүү бусад байгууллага дахь өөрийн хувь оролцоог хэмжинэ. Хяналт тавигч байгууллага нь уг анх мөрдөх өдрийн яг өмнөх тайлант жилийг буцаах горимоор залруулна. Байгууллага нь

бусад байгууллагад оролцоотой болсон (гэвч энэ Стандартад заасан, хяналтыг олж аваагүй) эсвэл хяналтаа алдсан өдөр нь уг яг өмнөх тайлант үеийн эхлэлээс өмнө байх тохиолдолд хяналт тавигч байгууллага нь дараах дүнгүүдийн хоорондох аливаа зөрүүг тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэнд цэвэр хөрөнгө/өмчийн залруулга байдлаар хүлээн зөвшөөрнө:

- (а) Хөрөнгө, өр төлбөр, хяналтын бус хувь оролцооны уг өмнөх дансны үнэ; ба
- (б) Бусад байгууллага дахь тухайн байгууллагын хувь оролцооны хүлээн зөвшөөрсөн дүн.

78. Бусад байгууллага дахь хувь оролцоог 77-р параграфын дагуу хэмжих практик боломжгүй бол (УСНББОУС 3-д тодорхойлсон) хяналт тавигч байгууллага нь 77-р параграфыг мөрдөх практик боломжтой хамгийн өмнөх тайлант үеийн, магадгүй тухайн тайлант үеийн эхнээс энэхүү Стандартын шаардлагуудыг мөрдөнө. Энэ параграфыг мөрдөх практик боломжтой хамгийн эхний тайлант үеийн эхлэл нь тухайн тайлант үе байхаас бусад тохиолдолд хяналт тавигч байгууллага нь уг анх мөрдөх өдрийн яг өмнөх тайлант жилийг буцаах горимоор залруулна. Тухайн байгууллага нь бусад байгууллагад оролцоотой болсон (гэвч энэ Стандартад заасан, хяналтыг олж аваагүй) эсвэл хяналтаа алдсан өдөр нь уг яг өмнөх тайлант үеийн эхлэлээс өмнө байх тохиолдолд хяналт тавигч байгууллага нь дараах дүнгүүдийн хоорондох аливаа зөрүүг тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэнд цэвэр хөрөнгө/өмчийн залруулга байдлаар хүлээн зөвшөөрнө:

- (а) Хөрөнгө, өр төлбөр, хяналтын бус хувь оролцооны уг өмнөх дансны үнэ; ба
- (б) Бусад байгууллага дахь тухайн байгууллагын хувь оролцооны хүлээн зөвшөөрсөн дүн.

Энэ параграфыг мөрдөх практик боломжтой хамгийн эхний тайлант үе нь тухайн тайлант үе байх тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчид хийх залруулгыг уг тайлант үеийн эхэнд хүлээн зөвшөөрнө.

## Хүчин төгөлдөр болох хугацаа

79. Байгууллага нь энэхүү Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, УСНББОУС 37, УСНББОУС 38-ыг мөрдөнө.

79А. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 11, 12, 13-р параграфуудыг хасаж, 8-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт

өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 79Б. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 6-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.
- 79В. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 4, 40, 56, 57, 63-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
- 79Г. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 52-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 55А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС3-өөс тодорхойлсон өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд гүйцээх горимоор мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дурдсан өдрөөс өмнө мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд хэрэв хараахан мөрдөөгүй байгаа бол тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
80. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## **УСНББОУС 6 (2006 оны 12 дугаар сар)-гаас татгалзах ба орлуулах**

81. Энэ Стандартыг УСНББОУС 34-ийн хамт гаргасан. Энэхүү хоёр Стандарт нь хамтдаа УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан* (2006

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

оны 12 дугаар сар)-г орлоно. УСНББОУС 34, УСНББОУС 35-ыг мөрдөх эсвэл эдгээр Стандартууд хүчин төгөлдөр болох хугацааны аль түүвэнд болох өдөр хүртэл УСНББОУС 6 нь мөрдөгдсөн хэвээр байна.



## Хавсралт А

### Мөрдөх заавар удирдамж

*Энэ Хавсралт нь УСНББОУС 35-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

МЗУ1. Энэ Хавсралт дахь жишээнүүд нь таамагласан нөхцөл байдлуудыг илэрхийлнэ. Хэдийгээр эдгээр жишээний зарим төлөв байдал нь бодит нөхцөл байдалд илрэн гарч болох боловч УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-г мөрдөх үедээ тухайн тодорхой хэв загварын бүх баримт материал болон нөхцөл байдлыг үнэлэх шаардлагатай байдаг.

### Хяналтыг үнэлэх

МЗУ2. Байгууллага нь бусад байгууллагыг хянадаг эсэхээ тодорхойлохын тулд түүнд дараах бүх зүйлс байгаа эсэхийг үнэлнэ:

- (а) Уг бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй;
- (б) Бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх хувьсах өгөөжийн хувьд хүлээх эрсдэлтэй эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй; ба
- (в) Бусад байгууллага дахь оролцооны өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөөлөхийн тулд тэрхүү бусад байгууллага дахь өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломжтой.

МЗУ3. Дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх нь ийм тодорхойлолт гаргахад тусалцаа үзүүлж болох юм:

- (а) Бусад байгууллагын зорилго ба бүтэц (МЗУ5-МЗУ8-р параграфыг үзнэ үү);
- (б) Холбогдох үйл ажиллагаа нь юу болох эсэх ба тэдгээр үйл ажиллагааны талаархи шийдвэрийг хэрхэн гаргадаг эсэх (МЗУ13-МЗУ15-р параграфыг үзнэ үү);
- (в) Тухайн байгууллагын эрх нь бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг түүнд олгодог эсэх (МЗУ16-МЗУ56-р параграфыг үзнэ үү);
- (г) Тухайн байгууллага нь бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх хувьсах өгөөжийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй эсэх (МЗУ57-МЗУ58-р параграфыг үзнэ үү); ба
- (д) Тухайн байгууллага нь бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөөлөхийн тулд тэрхүү бусад байгууллага дахь өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломжтой эсэх (МЗУ60-МЗУ74-р параграфыг үзнэ үү).

МЗУ4. Байгууллага нь бусад байгууллагыг хянадаг эсэхээ үнэлэхийн тулд бусад талуудтай холбогдох өөрийн харилцааны шинж төрлийг харгалзан үзнэ (МЗУ75-МЗУ77-р параграфыг үзнэ үү).

**Бусад байгууллагын зорилго ба бүтэц**

- МЗУ5. Холбогдох үйл ажиллагаа, түүнчлэн холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэрийг хэрхэн гаргадаг, хэн тэдгээр холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар боломжтой байдаг, хэн тэдгээр үйл ажиллагааны өгөөжийг хүртдэг эсэхийг тогтоохын тулд тухайн байгууллага нь хяналтын зорилгоор үнэлэгдэж буй уг бусад байгууллагын зорилго ба бүтцийг харгалзан үзнэ.
- МЗУ6. Хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллагын зорилго ба бүтцийг харгалзан үзэх тохиолдолд эзэмшигчдээ хувь тэнцүүлсэн саналын эрх олгодог энгийн хувьцаа гэх мэт өмчийн хэрэглүүрээр дамжуулан уг хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллагыг хянадаг гэдэг нь ойлгомжтой тодорхой байж болох юм. Ийм тохиолдолд шийдвэр гаргалтыг өөрчлөх ямар нэг нэмэлт хэлцэл тохиролцоо байхгүй бол хяналтын үнэлгээ нь уг хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн бодлогыг тодорхойлох хангалттай саналын эрхийг хэрэгжүүлж чадах тийм аливаа оролцогч талд голлон чиглэдэг (МЗУ32-МЗУ52-р параграфыг үзнэ үү). Хамгийн энгийн хялбар тохиолдолд хэрэв өөр бусад ямар нэг хүчин зүйлс байхгүй бол саналын эрхийн олонхи хувийг эзэмшдэг байгууллага нь уг бусад байгууллагыг хянадаг.
- МЗУ7. Байгууллага нь бусад байгууллагыг хянадаг эсэхийг илүү нарийн төвөгтэй нөхцөл байдалд тодорхойлохын тулд МЗУ3-р параграфт дурдсан, зарим буюу бүх бусад хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байж болно.
- МЗУ8. Хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллагыг хэн хянадаг эсэхийг шийдвэрлэхэд саналын эрх нь голлох хүчин зүйл биш байж болох юм. Хэрэв саналын эрх бол тэдгээр нь цар хүрээний хувьд хязгаарлагдсан байж болно. Хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллагын холбогдох үйл ажиллагааг заавал биелүүлэх хэлцлээр, эсвэл холбоо нэгдлийн дүрэм, үүсгэн байгуулагчдын гэрээ гэх мэт үүсгэн байгуулах баримт бичгийн нөхцлүүдээр удирдан чиглүүлж болох юм. Ийм тохиолдолд хяналтын зорилгоор үнэлэгдэж буй бусад байгууллагын зорилго ба бүтцийн хувьд тухайн байгууллагын анхаарах зүйлс нь тэрхүү бусад байгууллага өртөнө гэж төлөвлөн зохиомжилсон эрсдэл, хамаарах талуудад шилжүүлэхээр зохиомжилсон эрсдэл, түүнчлэн зарим буюу бүх эрсдэлд уг байгууллага өртөх эсэх талаархи анхаарах зүйлсийг бас агуулсан байдаг. Эрсдлийн анхаарах зүйлсэд зөвхөн “доош чиглэсэн” эрсдэл төдийгүй “дээш чиглэсэн” эрсдэл мөн хамаарна.

**Бүрэн эрх**

- МЗУ9. Бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй байхын тулд тус байгууллага нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг түүнд олгох одоогийн эрхтэй байх ёстой. Бүрэн эрхийг үнэлэх зорилгын хувьд, зөвхөн бодит эрхүүд, түүнчлэн хамгаалалтын бус эрхүүдийг харгалзан үзнэ (МЗУ25-МЗУ31-р параграфыг үзнэ үү).

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- МЗУ10. Байгууллага бүрэн эрхтэй эсэх талаархи тодорхойлолт нь холбогдох үйл ажиллагаа, түүнчлэн холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах арга зам, боломжит хяналтанд буй байгууллагатай холбоотой тухайн байгууллагын болон бусад байгууллагуудын эрхээс хамаардаг.
- МЗУ11. Үүсгэн байгуулах баримт бичиг буюу зөвшөөрөл олгох хууль тогтоомж нь бусад байгууллагын эрхлэх үндсэн үйл ажиллагаа болон санхүүгийн ажиллагааг тусгайлан заадаг тохиолдолд үүсгэн байгуулагдсан уг бусад байгууллагын хувьд тухайн байгууллага нь бүрэн эрхтэй байдаг. Гэвч байгууллага нь бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй эсэхийг үнэлэхдээ бүх баримт материал ба нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай тул үүсгэн байгуулах баримт бичиг буюу хууль тогтоомжийн үр нөлөөг бусад давамгайлах нөхцөл байдлын хүрээнд үнэлдэг. Жишээлбэл; засгийн газраас хянадаггүй бусад байгууллагуудын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхийг тухайн хууль тогтоомжоор эсвэл бусад хууль тогтоомжоор олгодог бол хууль тогтоомжоор бий болгосон бөгөөд түүгээр хязгаарладаг эрхийн бичгийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг судалгаа, хөгжүүлэлтийн корпорацийн хувьд засгийн газар нь бүрэн эрхгүй байж болно.

### *Зохицуулалтын хяналт*

- МЗУ12. Зохицуулалтын хяналт нь энэ Стандартын зорилгод хамаарах байгууллагын бүрэн эрхийг ихэвчлэн бий болгодоггүй. Засгийн газар ба улсын секторын бусад байгууллагууд, үүн дотроо үндэстэн дамнасан байгууллагууд нь бусад байгууллагуудын үйл ажиллагаагаа явуулах зохицуулалтын хүрээг тодорхойлох, тэдгээрийн үйл ажиллагааны нөхцөл буюу хариуцлагын арга хэмжээг тогтоох, уг нөхцөл буюу хариуцлагын арга хэмжээний хэрэгжилтийг хангах өргөн хүрээний бүрэн эрхтэй байж болно. Жишээлбэл; засгийн газар болон улсын секторын бусад байгууллагууд нь иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, аюултай бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах буюу ашиглахаас сэргийлэх, монополь үнэ тогтоох бодлогыг тусгайлан тодорхойлсон зохицуулалтуудын хэрэгжилтийг хангаж болох юм. Гэвч зохицуулалт нь байгууллага өөрийн үйл ажиллагааг хэрхэн явуулахыг бүрэн зааварчлах байдлаар хэт хатуу байх тохиолдолд түүний зорилго ба бүтэц нь тухайн байгууллагыг уг зохицуулагч байгууллага хянадаг юм шиг тийм байгаа эсэхийг харгалзан үзэх шаардлагатай байж болно.

### *Холбогдох үйл ажиллагаа ба холбогдох үйл ажиллагааны удирдан чиглүүлэлт*

- МЗУ13. Олон байгууллагуудын хувьд, үндсэн үйл ажиллагааны болон санхүүжилтийн үйл ажиллагааны муж нь тэдгээрийн бий болгох өгөөжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Хяналтанд буй байгууллагын зорилтуудад хүрэх буюу чиглэн ажиллахад туслах аливаа үйл ажиллагаа нь хяналт тавигч байгууллагын хүртэх өгөөжид нөлөөлж болох юм. Нөхцөл байдлаас хамааран холбогдох үйл ажиллагаа байж болох үйл ажиллагааны жишээнд дараах үйл ажиллагаа хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- (а) Үйлчилгээ хүлээн авагчдад үйлчилгээ үзүүлэхийн тулд хөрөнгийг ашиглах ба өр төлбөрийг хариуцах;
  - (б) Тусгайлан заасан хувь хүмүүс буюу бүлэгт мөнгө санг хуваарилах;
  - (в) Арилжааны бус ажил гүйлгээгээр дамжуулан орлогыг цуглуулах;
  - (г) Бараа, үйлчилгээг худалдан авах буюу борлуулах;
  - (д) Биет хөрөнгүүдийг удирдан зохицуулах;
  - (е) Санхүүгийн хөрөнгийг түүний хугацааны туршид (үүн дотроо, үл биелүүлэлт үүссэн үед) удирдан зохицуулах;
  - (ж) Хөрөнгүүдийг сонгох, худалдан авах эсвэл данснаас хасах;
  - (и) Өр төлбөрүүдийн багцыг удирдан зохицуулах;
  - (к) Шинэ бүтээгдэхүүн буюу процессыг судлах ба хөгжүүлэх; ба
  - (л) Санхүүжилтийн бүтцийг тодорхойлох буюу санхүүжилтийг олж авах.
- МЗУ14. Холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэрийн жишээнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
- (а) Байгууллагын үйл ажиллагааны болон капиталын шийдвэр, үүн дотроо төсвийг тогтоох; ба
  - (б) Байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон үйлчилгээний нийлүүлэгчдийг сонгож томилох, цалин урамшуулал олгох ба тэдний үйлчилгээ буюу ажил эрхлэлтийг дуусгавар болгох.
- МЗУ15. Зарим тохиолдолд, тодорхой цогц нөхцөл байдал үүсэх эсвэл үйл явдал гарч тохиолдохын өмнөх болон дараах үйл ажиллагааны аль аль нь холбогдох үйл ажиллагаа байж болох юм. Хэрэв хоёр буюу хэд хэдэн байгууллагууд нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар боломжтой бөгөөд тэдгээр үйл ажиллагаа нь өөр өөр цаг хугацаанд гарч тохиолддог бол байгууллагууд нь хамтын шийдвэр гаргах эрхийн арга хандлагатай нийцсэн байдлаар тэдгээр өгөөжид хамгийн их мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үйл ажиллагааг аль байгууллага удирдан чиглүүлж чадахыг тодорхойлно (28-р параграфыг үзнэ үү). Холбогдох баримт материал буюу нөхцөл байдал өөрчлөгдвөл тэдгээр хамаарах байгууллагууд нь энэхүү үнэлгээг цаг хугацааны явцад дахин харгалзан үзнэ.
- Бусад байгууллага дахь бүрэн эрхийг тухайн байгууллагад олгодог эрх*
- МЗУ16. Бүрэн эрх нь эрхээс үүсдэг. Бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй байхын тулд тус байгууллага нь уг бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар боломжийг түүнд олгох эрхтэй байх ёстой. Байгууллагад бүрэн эрхийг олгож болох эрхүүд нь янз бүр байж болно.

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЗУ17. Дангаараа эсвэл нэгдсэн байдлаараа тухайн байгууллагад бүрэн эрх олгох эрхүүдийн жишээнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Бусад байгууллагын удирдах байгууллагад бодлогын заавар чиглэл өгөх ба уг бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвар боломжийг түүний эзэмшигчид олгодог эрх;
- (б) Бусад байгууллагын саналын эрх (буюу боломжит саналын эрх) хэлбэрээр байх эрхүүд (МЗУ32-МЗУ52-р параграфыг үзнэ үү);
- (в) Холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвар боломж бүхий уг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан гишүүдийг томилох, ажил үүргийг өөрчлөх, халах эрх;
- (г) Холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг бусад байгууллагыг сонгон томилох буюу цуцлах эрх;
- (д) Бусад байгууллагын холбогдох үйл ажиллагаанд хамаарах үйл ажиллагааны болон капиталын төсвийг батлах эсвэл хориг тавих эрх;
- (е) Тухайн байгууллагын өгөөжийн төлөө ажил гүйлгээ хийлгэхээр бусад байгууллагыг удирдан чиглүүлэх эсвэл ажил гүйлгээний аливаа өөрчлөлтөнд хориг тавих эрх;
- (ж) Бусад байгууллагын гол хөрөнгө эсвэл уг бусад байгууллагыг бүхэлд нь худалдах гэх мэт бусад байгууллагын гол өөрчлөлтөнд хориг тавих эрх; ба
- (и) Холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвар боломжийг өөрийн эзэмшигчдээ олгодог бусад эрх (менежментийн гэрээнд тусгайлан заасан шийдвэр гаргах эрх гэх мэт).

МЗУ18. Бүрэн эрхтэй эсэхээ харгалзан үзэхдээ, тухайн байгууллага нь хүчин төгөлдөр үйлчилж буй заавал биелүүлэх хэлцэл болон бүрэн эрхийг олж авсан механизмыг авч үзэх шаардлагатай. Байгууллага дангаар нь, эсвэл бусад хэлцлүүдтэй нэгтгэн нийлүүлсэн байдлаар хяналтыг олж авч болох арга замуудад дараах зүйлс хамаарна:

- (а) Хууль тогтоох эсвэл засаглах бүрэн эрх;
- (б) Захиргааны арга хэмжээ;
- (в) Гэрээний тохиролцоо;
- (г) Үүсгэн байгуулах баримт бичиг (жишээлбэл; холбоо нэгдлийн дүрэм); ба
- (д) Саналын буюу адилтгах эрхүүд.

МЗУ19. Байгууллага нь түүнд бүрэн эрх олгох хангалттай эрхтэй эсэхийг тодорхойлохын тулд тухайн байгууллага нь бусад байгууллагын зорилго ба бүтэц (МЗУ5-МЗУ8-р параграфыг үзнэ үү), түүнчлэн МЗУ53-МЗУ56-р

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

параграфын шаардлагуудыг МЗУ20-МЗУ22-р параграфын шаардлагуудын хамт харгалзан үзнэ.

- МЗУ20. Зарим тохиолдолд байгууллагын эрх нь бусад байгууллагын хувьд түүнд бүрэн эрх олгоход хангалттай эсэхийг тодорхойлоход төвөгтэй байж болох юм. Ийм тохиолдолд бүрэн эрхийн үнэлгээг хийх боломжтой болохын тулд тухайн байгууллага нь холбогдох үйл ажиллагааг өөрөө дангаараа удирдан чиглүүлэх практик чадвар боломжтой эсэх талаархи нотолгоог харгалзан үзнэ. МЗУ21, МЗУ22-р параграфт дурдсан, түүний эрхүүд болон шинж тэмдгүүдийн хамт авч үзэхэд тухайн байгууллагын эрхүүд нь уг бусад байгууллагын хувьд түүнд бүрэн эрх олгоход хангалттай гэсэн нотолгоогоор хангаж болох тохиолдолд дараах зүйлсийг хамруулан харгалзан үзэх боловч үүгээр хязгаарлагдахгүй:
- (а) Гэрээний дагуу ийм эрхгүй боловч байгууллага нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвар боломж бүхий уг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилох буюу зөвшөөрөн баталдаг;
  - (б) Гэрээний дагуу ийм эрхгүй боловч байгууллага нь өөрийн ашиг тусын төлөө томоохон ажил гүйлгээ хийлгэхээр бусад байгууллагыг удирдан чиглүүлэх эсвэл тийм ажил гүйлгээний аливаа өөрчлөлт хийхийг хориглож чаддаг;
  - (в) Хөрөнгө оруулагч нь санхүүжигчийн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох нэр дэвшүүлэлт буюу бусад эзэмшигчдийн саналын эрхийн төлөөллийг олж авах үйл явцад давуу байр суурьтай байдаг;
  - (г) Бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь тухайн байгууллагын холбоотой тал байх (жишээлбэл; бусад байгууллагын гүйцэтгэх захирал ба тухайн байгууллагын гүйцэтгэх захирал нь нэг хүн байх); ба
  - (д) Бусад байгууллагын удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь тухайн байгууллагын холбоотой тал байх.
- МЗУ21. Зарим үед байгууллага нь бусад байгууллагатай тусгай харилцаатай, өөрөөр хэлбэл байгууллага нь тухайн бусад байгууллагын хувьд идэвхигүй хувь оролцооноос илүү оролцоотой гэдгийг илэрхийлэх шинж тэмдгүүд байдаг. Тодорхой нэг шинж тэмдэг эсвэл хэд хэдэн шинж тэмдгүүд хамтарсан байдлаар оршин байх нь бүрэн эрхийн шалгуур хангагдсан гэдэг утгыг заавал илэрхийлэх албагүй юм. Гэвч бусад байгууллагад идэвхигүй хувь оролцооноос илүү оролцоотой байх нь түүнд бүрэн эрх олгоход хангалттай өөр бусад холбогдох эрх тухайн байгууллагад байгаа гэдгийг илэрхийлж болно эсвэл уг бусад байгууллагын хувьд одоогийн бүрэн эрхтэй гэсэн нотолгоогоор хангаж болох юм. Жишээлбэл; байгууллага нь уг бусад байгууллагын хувьд идэвхигүй хувь оролцооноос илүү оролцоотой бөгөөд бусад эрхүүдтэй хамтарснаар бүрэн эрхийг төлөөлж болох юм гэдгийг дараах зүйлс илэрхийлдэг:

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- (а) Бусад байгууллагын үйл ажиллагаа нь дараах гэх мэт нөхцөл байдалд тухайн байгууллагын үйл ажиллагаанаас хамааралтай байдаг:
- (i) Байгууллага нь бусад байгууллагын үйл ажиллагааны мэдэгдэхүйц хэсгийг санхүүжүүлдэг ба уг бусад байгууллага нь түүнээс хамааралтай байх.
  - (ii) Байгууллага нь бусад байгууллагын өр төлбөрийн мэдэгдэхүйц хэсэгт баталгаа гаргадаг ба уг бусад байгууллага нь түүнээс хамааралтай байх.
  - (iii) Байгууллага нь гол чухал үйлчилгээ, технологи, хангамж буюу түүхий эд материалаар бусад байгууллагыг хангадаг ба уг бусад байгууллага нь түүнээс хамааралтай байх.
  - (iv) Байгууллага нь бусад байгууллагад чухал ач холбогдолтой лиценз, худалдааны тэмдэг гэх мэт хөрөнгүүдийг хянадаг ба уг бусад байгууллага нь түүнээс хамааралтай байх.
  - (v) Байгууллага нь эрх бүхий албан тушаалтнаар уг бусад байгууллагыг хангаж ажиллуулдаг (жишээлбэл; тухайн байгууллагын ажилтан нь уг бусад байгууллагын үйл ажиллагааны талаар тусгайлсан мэдлэгтэй байх) ба уг бусад байгууллага нь түүнээс хамааралтай байх.
- (в) Бусад байгууллагын үйл ажиллагааны мэдэгдэхүйц хэсэг нь тухайн байгууллагатай холбоотой эсвэл түүний өмнөөс хийгддэг байх.
- (г) Бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьд тухайн байгууллагын хүлээх эрсдэл эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрх нь түүний саналын эрх болон бусад адилтгах эрхтэй хувь тэнцүү биш, илүү өндөр байх. Жишээлбэл; байгууллага нь бусад байгууллагын өгөөжийн тэн хагасаас илүүг авах эрхтэй буюу ийм хэмжээний эрсдлийг хүлээдэг боловч уг бусад байгууллагын саналын эрхийн тэн хагасаас бага хэсгийг эзэмшдэг байж болно.
- МЗУ22. МЗУ21-р параграфт жагсаан харуулсан үзүүлэлтүүдийн үр дүнд улсын секторын байгууллагууд нь бусад талуудтай ихэвчлэн тусгай харилцаа холбоотой байдаг. Улсын секторын байгууллагууд нь бусад байгууллагуудын үйл ажиллагааг ихэвчлэн санхүүжүүлдэг. Эдийн засгийн хараат байдлыг МЗУ41-МЗУ42-р параграфт авч хэлэлцсэн.
- МЗУ23. Бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд байгууллагын хүлээх эрсдэл эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрх нь их байх тусам түүнд бүрэн эрх олгоход хангалттай эрхийг олж авах тухайн байгууллагын сэдэл санаачлага их байдаг. Иймээс өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд их эрсдэл хүлээж байгаа нь тухайн байгууллага бүрэн эрхтэй байж болохыг илтгэх шинж тэмдэг юм. Гэхдээ байгууллагын хүлээх эрсдлийн хэмжээ нь бусад байгууллагын хувьд тухайн байгууллага бүрэн эрхтэй эсэхийг дангаараа тодорхойлохгүй.

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЗУ24. МЗУ20-р параграфт дурдсан хүчин зүйлс, МЗУ21-МЗУ23-р параграфт заасан шинж тэмдгүүдийг тухайн байгууллагын эрхүүдийн хамт авч үзэх тохиолдолд МЗУ20-р параграфт дурдсан бүрэн эрхийн нотолгоонд илүү их хувийн жин өгнө.

### Бодит эрхүүд

МЗУ25. Бүрэн эрхтэй эсэхээ үнэлэхийн тулд байгууллага нь бусад байгууллагатай холбоотой зөвхөн бодит эрхүүдийг (тухайн байгууллага ба бусад талуудын эзэмшиж буй) харгалзан үзнэ. Эрх нь бодит байхын тулд эзэмшигч нь уг эрхийг хэрэгжүүлэх практик чадвар, боломжтой байх ёстой.

МЗУ26. Эрх бодит эсэхийг тодорхойлохын тулд бүх баримт материал ба нөхцөл байдлуудыг харгалзан шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Ингэж тодорхойлохын тулд харгалзан үзэх хүчин зүйлсэд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (a) Эзэмшигч (буюу эзэмшигчид) нь тухайн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах ямар нэг хориг саад (эдийн засгийн буюу бусад) байгаа эсэх. Ийм хориг саадын жишээнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
  - (i) Эзэмшигч нь эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах (буюу зогсоох) санхүүгийн торгууль шийтгэл болон сэдэл урамшуулал.
  - (ii) Эзэмшигч нь эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах (буюу зогсоох) санхүүгийн хориг саад үүсгэх хэрэгжүүлэлтийн буюу хөрвүүлэлтийн үнэ.
  - (iii) Эрхээ хэрэгжүүлэх магадлал багатай болгох нөхцөл ба болзол, тухайлбал; тэдгээрийн хэрэгжүүлэх хугацааг хавчин хязгаарлах нөхцлүүд.
  - (iv) Эзэмшигч нь өөрийн эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгох зохих ул үндэслэлтэй, тодорхой механизм нь уг бусад байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт болон холбогдох хууль, тогтоомжид заагаагүй байх.
  - (v) Эрхийн эзэмшигч нь өөрийн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг олж авах чадвар, боломжгүй байх.
  - (vi) Эзэмшигч нь өөрийн эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулах (буюу зогсоох) үйл ажиллагааны хориг саад буюу сэдэл урамшуулал (жишээлбэл; уг тусгай мэргэшсэн үйлчилгээг үзүүлэхэд бэлэн буюу үзүүлэх чадвартай, эсвэл тухайн хариуцсан менежерийн үйлчилгээг үзүүлэх ба бусад хувь оролцоог орлон гүйцэтгэх өөр бусад менежерүүд байхгүй байх).



## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(vii) Эзэмшигч нь эрхийг хэрэгжүүлэхийг хязгаарлах эсвэл өөрийн эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулах хуулийн буюу зохицуулалтын шаардлагууд (жишээлбэл; бусад байгууллага нь засгийн газраас хараат бус үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн хууль ёсны бүрэн эрхтэй байх эсвэл гадны байгууллага нь өөрийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглосон байх).

(б) Эрхийн хэрэгжүүлэлт нь нэгээс олон талууд хэлэлцэн тохирохыг шаарддаг буюу эрхийг нэгээс олон талууд эзэмшиж байгаа тохиолдолд, тэдгээр талууд нь эрхээ хамтран хэрэгжүүлэх сонголт хийсэн бол тэдэнд эрхээ хэрэгжүүлэх практик чадвар, боломж олгох механизм байгаа эсэх. Ийм механизм байхгүй байгаа нь тухайн эрх бодит биш гэдгийг илэрхийлэх шинж тэмдэг байж болно. Эрхийг хэрэгжүүлэхийн тулд тохиролцон зөвшөөрөх шаардлагатай талууд олон байх тусам тухайн эрх нь бодит байх магадлал төдий чинээ бага байдаг. Гэвч шийдвэр гаргагчаас хараат бус байх гишүүд бүхий захирлуудын зөвлөл (буюу бусад удирдах байгууллага) нь маш олон байгууллагууд (эсвэл бусад талууд) өөрсдийн эрхийг хэрэгжүүлэхээр хамтран ажиллах тийм механизмын үүргийг гүйцэтгэж болох юм. Иймээс хараат бус захирлуудын зөвлөл (буюу бусад удирдах байгууллага)-ийн хэрэгжүүлж болох цуцлах эрх нь олон тооны байгууллагууд (эсвэл бусад талууд) тухайн эрхийг тус тусдаа хэрэгжүүлэхээс илүү бодитой байх магадлалтай байдаг.

(в) Эрхийг эзэмшиж буй нэг эсвэл хэд хэдэн талууд нь тэдгээр эрхийн хэрэгжүүлэлтээр өгөөж хүртэх эсэх. Жишээлбэл; бусад байгууллагын боломжит саналын эрхийг эзэмшигч (МЗУ49-МЗУ52-р параграфыг үзнэ үү) нь уг хэрэглүүрийг хэрэгжүүлэх буюу хөрвүүлэх үнийг харгалзан үзнэ. Хэрэглүүр нь мөнгөн ашигтай эсвэл байгууллага нь бусад учир шалтгаанаар (жишээлбэл; тухайн байгууллага ба бусад байгууллагын хооронд өргөжилтийн хэмнэлтийг хэрэгжүүлснээр) тухайн хэрэглүүрийн хэрэгжүүлэлт буюу хөрвүүлэлтээс өгөөж хүртэх тохиолдолд боломжит саналын эрхийн нөхцөл, болзлууд нь бодитой байх илүү их магадлалтай байдаг.

МЗУ27. Бодитой байхын тулд эрх нь тухайн холбогдох үйл ажиллагааны удирдан чиглүүлэлтийн талаархи шийдвэрийг гаргах шаардлагатай болсон үед мөн хэрэгжих боломжтой байх ёстой. Бодитой байхын тулд эрх нь ихэвчлэн одоо хэрэгжүүлэх боломжтой байх ёстой. Гэвч эрхийг одоо хэрэгжүүлэх боломжгүй байлаа ч гэсэн эрх нь зарим үед бодит байж болно.

МЗУ28. Бусад талуудын хэрэгжүүлж чадах бодит эрхүүд нь тэдгээр эрхүүд хамаарах уг хяналтын зорилгоор үнэлэгдэж буй бусад байгууллагыг тухайн байгууллага хянахад саад учруулдаг. Ийм бодит эрх нь түүний эзэмшигч тухайн шийдвэрийг санаачлан гаргах чадвар, боломжтой байхыг шаарддаггүй. Бусад талуудын эзэмшиж буй бодит эрхүүд нь

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэрийг зөвхөн зөвшөөрөн батлах эсвэл хориглон саатуулах одоогийн чадвар, боломжийг өөрийн эзэмшигчиддээ олгодог хэдий ч ийм эрхүүд нь зөвхөн хамгаалалтын шинжтэй биш бол (МЗУ29-МЗУ31-р параграфыг үзнэ үү) тэдгээр нь хяналтын зорилгоор үнэлэгдэж буй уг бусад байгууллагыг тухайн байгууллага хянахад саад учруулж болох юм.

### *Хамгаалалтын эрх*

- МЗУ29. Эрх нь бусад байгууллагын бүрэн эрхийг тухайн байгууллагад олгодог эсэхийг үнэлэхдээ, тус байгууллагын өөрийн эрх, түүнчлэн бусад талуудын эзэмшиж буй эрх нь хамгаалалтын эрх эсэхийг уг байгууллага нь харгалзан үзнэ. Хамгаалалтын эрх нь бусад байгууллагын үйл ажиллагааны үндсэн өөрчлөлтүүдтэй холбоотой байдаг бөгөөд хэвийн бус гажих нөхцлүүдэд түүнийг хэрэглэдэг. Гэвч хэвийн бус, гажих нөхцлүүдэд хэрэглэдэг эсвэл үйл явдлуудаас болзошгүй хамаарах бүх эрх нь хамгаалалтын эрх байх албагүй юм (МЗУ15, МЗУ55-р параграфыг үзнэ үү).
- МЗУ30. Хамгаалалтын эрх нь түүний хамаарах байгууллагын хувьд бүрэн эрхийг тухайн эзэмшигч талд олгохгүйгээр тэрхүү эзэмшигчийн хувь оролцоог хамгаалах зориулалттай байдаг тул зөвхөн хамгаалалтын эрхийг эзэмшиж буй байгууллага нь тухайн эрх хамаарах байгууллагын хувьд бүрэн эрхгүй буюу өөр тал ийм бүрэн эрхтэй байхад саад учруулж чадахгүй (29-р параграфыг үзнэ үү).
- МЗУ31. Хамгаалалтын эрхийн жишээнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
- (а) Зээлдүүлэгчид хохирол учруулах байдлаар зээлдэгчийн зээлийн эрсдлийг мэдэгдэхүйц өөрчилж болох үйл ажиллагааг тухайн зээлдэгч явуулахыг хязгаарласан зээлдүүлэгчийн эрх.
  - (б) Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад шаардлагатай хэмжээнээс илүү их капитал зарлагыг зөвшөөрөн батлах, эсвэл өмчийн болон өрийн хэрэглүүр гаргахыг зөвшөөрөн батлах уг байгууллагын хяналтын бус хувь оролцоог эзэмшиж буй талын эрх.
  - (в) Хэрэв зээлдэгч нь зээлийг буцаан төлөх тохиролцсон нөхцлийг ханган биелүүлээгүй бол түүний хөрөнгийг авах уг зээлдүүлэгчийн эрх.
  - (г) Хууль тогтоомж буюу бусад шаардлагуудыг даган мөрдөөгүй байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох буюу хаах зохицуулагчийн эрх. Жишээлбэл, бохирдлын хяналтын эрх бүхий байгууллага нь байгаль орчны хууль тогтоомжийг зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг зогсоож болох юм.
  - (д) Зарим цөөн нөхцөл байдалд бусад байгууллагын удирдах байгууллагын гишүүдийг чөлөөлөх эрх. Жишээлбэл; хэрэв хотын захиргаа нь гол бодлогын шийдвэрүүдийг цаг хугацаанд нь гаргаж

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

чадахгүй байвал мужийн засгийн газар нь хотын даргыг огцруулах буюу түдгэлзүүлж, захирагчийг томилж болох юм.

- (е) Хэрэв тухайн байгууллага нь өөрийн зорилго буюу үйл ажиллагааг эрс өөрчилвөл ашгийн төлөө бус байгууллагад олгосон хувь оролцооны хувьд татвараас чөлөөлөх заалтыг хасах засгийн газрын эрх.
- (ж) Хэрэв буяны байгууллага татан буугдвал түүний цэвэр хөрөнгийг ижил төсөөтэй үйл ажиллагаа явуулдаг өөр байгууллагад хуваарилан олгох нөхцөлтэйгээр тэрхүү буяны байгууллагад нөөцийг олгох тухайн байгууллагын эрх. (Буяны байгууллага татан буугдвал тухайн байгууллага нь түүний цэвэр хөрөнгийг хуваарилан олгох нөхцлийг тусгайлан тодорхойлсон бүрэн эрхтэй бол тэрхүү байгууллага нь уг буяны байгууллагын хувьд бодит эрхтэй байна).

### *Саналын эрх*

МЗУ32. Хэрэв байгууллага нь бусад байгууллагын хувьд саналын буюу адилтгах эрхтэй бол тэдгээр эрх нь уг бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар боломжийг түүнд олгох эсэхийг тухайн байгууллага харгалзан үзнэ. Ийм үнэлгээг хийхдээ тухайн байгууллага нь энэ хэсэгт дурдсан шаардлагуудыг (МЗУ33-МЗУ52-р параграф) харгалзан үзнэ.

### Олонхийн саналын эрх бүхий бүрэн эрх

МЗУ33. МЗУ34 эсвэл МЗУ35-р параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд, бусад байгууллагын саналын эрхийн тэн хагасаас илүүг эзэмшиж буй байгууллага нь дараах нөхцөлд бүрэн эрхтэй байна:

- (а) Олонхийн саналын эрхийг эзэмшигчийн саналаар тухайн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг; эсвэл
- (б) Олонхийн саналын эрхийг эзэмшигчийн саналаар тухайн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийг томилдог.

### Олонхийн саналын эрхтэй боловч бүрэн эрхгүй байх

МЗУ34. Бусад байгууллагын саналын эрхийн тэн хагасаас илүүг эзэмшиж буй байгууллага нь уг бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй байхын тулд, тухайн байгууллагын саналын эрх нь МЗУ25-МЗУ28-р параграфт заасанчлан, бодитой байх ёстой бөгөөд холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг түүнд олгодог байх ёстой. Одоогийн чадвар, боломж нь үйл ажиллагааны болон санхүүгийн бодлогыг тодорхойлсноор ихэвчлэн хэрэгждэг. Хэрэв өөр байгууллага нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрхийг тухайн байгууллагад олгох одоогийн эрхтэй бөгөөд тэрхүү байгууллага нь хяналтын үнэлгээ хийж буй байгууллагын төлөөлөн оролцогч биш бол

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

хяналтын үнэлгээ хийж буй уг байгууллага нь бусад байгууллагын хувьд бүрэн эрхгүй байна.

МЗУ35. Байгууллага нь бусад байгууллагын саналын эрхийн олонхийг эзэмшдэг боловч тэдгээр саналын эрх нь бодитой бус байх тохиолдолд тухайн байгууллага нь бусад байгууллагын хувьд бүрэн эрхгүй байна. Жишээлбэл; холбогдох үйл ажиллагаа нь засгийн газар, шүүх, төрийн захиргааны байгууллага, эрх хүлээн авагч, татан буулгагч буюу зохицуулагч байгууллагын удирдан чиглүүлэлтэнд орсон тохиолдолд уг бусад байгууллагын саналын эрхийн тэн хагасаас илүүг эзэмшиж буй байгууллага нь бүрэн эрхгүй байна.

Олонхийн саналын эрхгүй бүрэн эрх

МЗУ36. Байгууллага нь бусад байгууллагын саналын эрхийн олонхи биш хэсгийг эзэмшдэг боловч бүрэн эрхтэй байж болно. Тухайн байгууллага нь бусад байгууллагын олонхийн саналын эрхгүй боловч тухайлбал, дараах зүйлсээр дамжуулан бүрэн эрхтэй байж болно:

- (а) Захирлуудын зөвлөлийн (буюу бусад удирдах байгууллагын) гишүүдийн олонхийг томилох эсвэл чөлөөлөх бүрэн эрх, түүнчлэн уг бусад байгууллагад тэрхүү зөвлөл буюу удирдах байгууллагын тавих хяналт (МЗУ38-р параграфыг үзнэ үү);
- (б) Тухайн байгууллага ба саналын эрхийн бусад эзэмшигчдийн хоорондох заавал биелүүлэх хэлцэл (МЗУ39-р параграфыг үзнэ үү);
- (в) Заавал биелүүлэх бусад хэлцлээс үүсэх эрх (МЗУ40-р параграфыг үзнэ үү);
- (г) Тухайн байгууллагын саналын эрх (МЗУ37, МЗУ43-МЗУ48-р параграфыг үзнэ үү);
- (д) Боломжит саналын эрх (МЗУ49-МЗУ52-р параграфыг үзнэ үү); эсвэл
- (е) Дээрх (а)-(д)-д заасан зүйлсийн хослол.

Өмчлөлийн хувь оролцоонд хамаарах тусгай саналын эрх (Алтан хувьцаа)

МЗУ37. Байгууллага нь шийдвэрлэх санал өгөх эрхтэй, иймээс уг бусад байгууллагын бусад бүх саналын эрхийг хориглох эрхтэй байж болох юм. Энэ төрлийн эрхийг зарим үед “алтан хувьцаа” гэж нэрлэдэг. Уг тусгай саналын эрх нь бүрэн эрхийг олгодог байж болно. Ийм эрхийг уг бусад байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт (байгууллагын дүрэм гэх мэт) ихэвчлэн баримтжуулан тусгадаг бөгөөд тодорхой зарим талуудын эзэмшиж буй саналын буюу бусад эрхийн түвшинг хязгаарлах зорилготой байдаг. Мөн энэ нь бусад байгууллагын гол хөрөнгө эсвэл уг бусад байгууллагыг бүхэлд нь худалдах гэх мэт түүний аливаа томоохон өөрчлөлтөнд хориг тавих бүрэн эрхийг тухайн байгууллагад олгож болох юм.

Захирлуудын зөвлөл ба бусад удирдах байгууллагын хяналт

МЗУ38. Байгууллага нь заавал биелүүлэх хэлцлийн (үүн дотроо, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, засаглах эрх, зохицуулалт, гэрээний тохиролцоо буюу бусад хэлцлийн) үр дүнд захирлуудын зөвлөлийн (буюу бусад удирдах байгууллагын) гишүүдийн олонхийг томилох эсвэл чөлөөлөх бүрэн эрхтэй байж болно.

Саналын эрхийн бусад эзэмшигчидтэй хийсэн заавал биелүүлэх хэлцэл

МЗУ39. Байгууллага нь заавал биелүүлэх хэлцэл байгуулаагүй бол түүнд бүрэн эрх олгох хангалттай саналын эрхгүй байсан боловч тухайн байгууллага ба саналын эрхийн бусад эзэмшигчдийн хоорондох заавал биелүүлэх хэлцлээр уг байгууллагад бүрэн эрх олгоход хангалттай саналын эрхийг хэрэгжүүлэх эрхийг тэрхүү байгууллагад олгож болох юм. Харин заавал биелүүлэх хэлцэл нь холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах боломжийг тухайн байгууллагад олгохын тулд саналын эрхийн бусад эзэмшигч нар хэрхэн саналаа өгөхийг уг байгууллага удирдан чиглүүлэх боломжийг бүрдүүлдэг байж болно.

Заавал биелүүлэх бусад хэлцлээс үүсэх эрх

МЗУ40. Саналын эрхийн хамтаар шийдвэр гаргах бусад эрхүүд нь тухайн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг уг байгууллагад олгож болох юм. Тухайлбал; саналын эрхийн хамтаар тэрхүү заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заасан эрхүүд нь байгууллагын хүртэх өгөөжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх уг бусад байгууллагын үйл ажиллагааны буюу санхүүгийн бодлого болон бусад гол үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг тухайн байгууллагад олгож болох юм. Харин бусад байгууллага нь (жишээлбэл; заавал биелүүлэх хэлцлийг биелүүлэхгүй байх ба үр дагаврыг хариуцах, эсвэл дүрмээ өөрчлөх буюу өөрийгөө татан буулгах замаар) өөрийн бодлого болон хөтөлбөрийг мэдэгдэхүйц хэмжээгээр тодорхойлох боломжтой бол тухайн байгууллага нь уг бусад байгууллагыг хянахгүй.

Эдийн засгийн хараат байдал

МЗУ41. Эдийн засгийн хараат байдал нь энэ Стандартын зорилгод хамаарах бүрэн эрхийг тухайн байгууллагад дангаараа олгохгүй. Дараах тохиолдолд эдийн засгийн хараат байдал үүсэж болох юм:

- (а) Байгууллага нь ганцхан том үйлчлүүлэгчтэй бөгөөд уг үйлчлүүлэгчээ алдах нь тухайн байгууллагын үйл ажиллагааны оршин байдалд нөлөө үзүүлж болох; эсвэл
- (б) Байгууллагын үйл ажиллагаа нь буцалтгүй тусламж ба хандиваар үндсэндээ санхүүждэг бөгөөд тус байгууллага нь ихэнх санхүүжилтийг нэг байгууллагаас авдаг.

МЗУ42. Байгууллага нь түүний санхүүжилтээс хамааралтай байдаг бусад байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогод нөлөөлөх боломжтой юм. Гэвч эдийн засгийн хувьд хараат байгууллага нь өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг удирдан чиглүүлэх эцсийн бүрэн эрхгүй тийм эдийн засгийн хараат байдалтай эсэхийг тодорхойлохын тулд хүчин зүйлсийг хослуулан харгалзан үзэх шаардлагатай байдаг. Хэрэв эдийн засгийн хараат байгууллага нь тухайн байгууллагаас санхүүжилт авах эсэх, эсвэл түүнтэй бизнес хийх эсэхээ өөрөө шийддэг бол уг эдийн засгийн хараат байгууллага нь өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг удирдан чиглүүлэх эцсийн бүрэн эрхтэй хэвээр байна. Жишээлбэл; засгийн газраас санхүүжилт авдаг боловч удирдах байгууллага нь уг санхүүжилтийг хүлээн авах эсэх болон мөнгө санг хэрхэн ашиглан зарцуулахыг өөрөө шийдвэрлэдэг хувийн сургууль нь санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогоо удирдан чиглүүлэх эцсийн бүрэн эрхтэй хэвээр байна. Тусгайлан заасан нөхцлүүдийг даган мөрдөхийг тухайн байгууллагаас шаардах байдлаар уг байгууллагад засгийн газрын санхүүжилтийг олгодог байлаа ч гэсэн ийм бүрэн эрхтэй байж болно. Хэдийгээр байгууллага нь тусгайлан заасан үйлчилгээний стандарт эсвэл хэрэглэгчдээс авах төлбөрийн хязгаарлалт бүхий нөхцөлтэйгээр капитал хөрөнгийн барилгын ажил болон үйл ажиллагааны зардалд зориулан засгийн газрын буцалтгүй тусламжийг хүлээн авч болох боловч түүний удирдах зөвлөл нь хөрөнгийг хэрхэн ашиглах талаар эцсийн бүрэн эрхтэй байж болно. Иймээс тухайн байгууллага нь өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогод хяналт тавьдаг. Байгууллагын үйл ажиллагаа ба тухайн байгууллагыг өөр хооронд нь ялгаж салгах нь мөн чухал ач холбогдолтой байдаг. Гол чухал үйлчлүүлэгчээ алдах нь тухайн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлж болох боловч уг байгууллагын оршин байдалд нөлөөлөхгүй байж болно.

#### Байгууллагын саналын эрх

МЗУ43. Олонхийн саналын эрхгүй байгууллага нь холбогдох үйл ажиллагааг дангаараа удирдан чиглүүлэх практик чадвар, боломжтой тохиолдолд түүнд бүрэн эрх олгоход хангалттай эрхүүдтэй байдаг.

МЗУ44. Байгууллагын саналын эрх нь түүнд бүрэн эрх олгоход хангалттай эсэхийг үнэлэхдээ, тухайн байгууллага нь бүх баримт материал ба нөхцөл байдлуудыг харгалзан үзнэ. Үүнд:

- (a) Саналын эрхийн бусад эзэмшигчдийн өмчлөлийн хэмжээ ба тархалттай харьцуулахад тухайн байгууллагын саналын эрхийн хэмжээ, үүнд дараах зүйлсийг анхаарах:
  - (i) Байгууллагын эзэмшиж буй саналын эрх их байх тусам холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг түүнд олгох эрх тухайн байгууллагад байх магадлал төдий чинээ өндөр байна;

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- (ii) Саналын эрхийн бусад эзэмшигчидтэй харьцуулахад байгууллагын эзэмшиж буй саналын эрх их байх тусам холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг түүнд олгох эрх тухайн байгууллагад байх магадлал төдий чинээ өндөр байна;
  - (iii) Уг байгууллагаас илүү саналтай болохын тулд хамтрах шаардлагатай талуудын тоо олон байх тусам холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг түүнд олгох эрх тухайн байгууллагад байх магадлал төдий чинээ өндөр байна;
- (б) Тухайн байгууллага, саналын эрхийн бусад эзэмшигчид буюу бусад талуудын эзэмшиж буй боломжит саналын эрхүүд (МЗУ49-МЗУ52-р параграфыг үзнэ үү);
  - (в) Заавал биелүүлэх бусад хэлцлээс үүссэн эрх (МЗУ40-р параграфыг үзнэ үү); ба
  - (г) Шийдвэр гаргах шаардлагатай болсон үед тухайн байгууллага нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжтой эсвэл ийм чадвар, боломжгүй гэдгийг илэрхийлэх аливаа нэмэлт баримт материал ба нөхцөл байдал, үүнд, өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал өгсөн байдал.
- МЗУ45. Холбогдох үйл ажиллагааны удирдан чиглүүлэлтийг олонхийн саналаар тодорхойлдог бөгөөд тухайн байгууллага нь саналын эрхийн аливаа бусад эзэмшигч буюу эзэмшигчдийн зохион байгуулалттай бүлгээс мэдэгдэхүйц олон саналын эрхийг эзэмшдэг ба хувьцааны бусад эзэмшилт нь ихээхэн тархсан тохиолдолд МЗУ44(а)-(в) параграфт жагсаан харуулсан хүчин зүйлсийг зөвхөн харгалзан үзсэний дараа, бусад байгууллагын хувьд уг байгууллага бүрэн эрхтэй гэдэг нь тодорхой харагдаж болох юм.
- МЗУ46. Өөр бусад тохиолдолд МЗУ44(а)-(в) параграфт жагсаан харуулсан хүчин зүйлсийг зөвхөн харгалзан үзсэний дараа, тухайн байгууллага бүрэн эрхгүй гэдэг нь тодорхой харагдаж болох юм.
- МЗУ47. Гэвч МЗУ44(а)-(в) параграфт жагсаан харуулсан хүчин зүйлс нь дангаараа дүгнэлтийн шинжтэй биш байж болно. Хэрэв эдгээр хүчин зүйлсийг харгалзан үзснээр байгууллага бүрэн эрхтэй эсэх нь тодорхой бус байвал тухайн байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн өмнөх хурлуудаар санал өгсөн байдлыг харахад бусад хувьцаа эзэмшигчид идэвхигүй шинж чанартай байсан гэх мэт бусад нэмэлт баримт материал болон нөхцөл байдлуудыг харгалзан үзнэ. Үүнд МЗУ20-р параграфт дурдсан хүчин зүйлс, МЗУ21-МЗУ23-р параграфт заасан шинж тэмдгүүдийн үнэлгээ хамаарна. Байгууллагын эзэмшиж буй саналын эрх бага ба уг байгууллагаас илүү саналтай болохын тулд хамтрах шаардлагатай талуудын тоо цөөн байх тусам тухайн байгууллагын эрх нь түүнд бүрэн эрх олгоход хангалттай эсэхийг үнэлэхийн тулд нэмэлт баримт материал болон нөхцөл байдлуудад төдий чинээ их найдлага

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

тавьдаг. МЗУ20-МЗУ23-р параграфт дурдсан баримт материал болон нөхцөл байдлуудыг тухайн байгууллагын эрхийн хамт харгалзан үзэх үедээ, МЗУ20-р параграфт дурдсан бүрэн эрхийн нотолгоонд МЗУ21-МЗУ23-р параграфт заасан бүрэн эрхийн шинж тэмдгээс илүү их ач холбогдол өгнө.

МЗУ48. МЗУ44(а)-(г) параграфт жагсаан харуулсан хүчин зүйлсийг харгалзан үзэхэд, байгууллага бүрэн эрхтэй эсэх нь тодорхойгүй бол тухайн байгууллага нь бусад байгууллагыг хянадаггүй гэсэн үг юм.

### Боломжит саналын эрх

МЗУ49. Хяналтыг үнэлэх үедээ байгууллага нь бүрэн эрхтэй эсэхээ тодорхойлохын тулд өөрийн боломжит саналын эрх, түүнчлэн бусад талуудын эзэмшиж буй боломжит саналын эрхийг харгалзан үзнэ. Боломжит саналын эрх гэдэг нь хөрвөх хэрэглүүр буюу опцион, түүнчлэн форвард гэрээнээс үүсдэг эрх гэх мэт бусад байгууллагын саналын эрхийг олж авах эрх юм. Эрх нь бодитой байх зөвхөн тийм тохиолдолд тэдгээр боломжит саналын эрхүүдийг харгалзан үзнэ (МЗУ25-МЗУ28-р параграфыг үзнэ үү).

МЗУ50. Боломжит саналын эрхийг авч үзэх үедээ байгууллага нь тухайн хэрэглүүрийн зорилго ба бүтэц, түүнчлэн бусад байгууллагатай өөрийн холбогдох аливаа бусад оролцооны зорилго ба бүтцийг харгалзан үзнэ. Үүнд уг хэрэглүүрийн янз бүрийн нөхцөл, болзлын талаархи үнэлгээ, түүнчлэн тэдгээр нөхцөл, болзлыг хүлээн зөвшөөрөх тухайн байгууллагын тодорхой хүлээлт, сэдэл урамшуулал, шалтгаан үндэслэл хамаарна.

МЗУ51. Хэрэв байгууллага нь бусад байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор саналын буюу бусад шийдвэр гаргах эрхтэй бол тэдгээр эрхүүд нь боломжит саналын эрхийн хамтаар түүнд бүрэн эрх олгох эсэхийг уг байгууллага үнэлнэ.

МЗУ52. Бодитой байгаа, боломжит саналын эрх нь дангаараа эсвэл бусад эрхүүдтэй хамтарснаар холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг тухайн байгууллагад олгож болох юм. Жишээлбэл; байгууллага нь бусад байгууллагын саналын эрхийн 40 хувийг эзэмшдэг бөгөөд цаашид саналын эрхийн 20 хувийг олж эзэмшихийн тулд опционоос үүсэх бодит эрхийг МЗУ26-р параграфын дагуу эзэмших бол ийм тохиолдох үүсэх магадлалтай байдаг.

*Саналын буюу түүнтэй ижил төсөөтэй эрхүүд нь өгөөжид мэдэгдэхүйц нөлөөгүй байх үеийн бүрэн эрх*

МЗУ53. Бусад байгууллагын зорилго ба бүтцийг үнэлэх үедээ (МЗУ5-МЗУ8-р параграфыг үзнэ үү), байгууллага нь өөрийн бүтцийн нэг хэсэг болгон уг бусад байгууллагын үүсгэн байгуулалтан дахь өөрийн оролцоо болон гаргасан шийдвэрээ харгалзан үзэх бөгөөд тухайн ажил гүйлгээний нөхцөл, оролцооны шинжүүд нь байгууллагад бүрэн эрх олгоход



хангалттай эрхээр түүнийг хангах эсэхийг үнэлнэ. Бусад байгууллагын бүтцэд зөвхөн оролцох нь тухайн байгууллагад хяналт өгөхөд хангалтгүй юм. Гэвч бусад байгууллагын бүтцэд оролцоотой байх нь уг бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй болоход хангалттай эрхийг тухайн байгууллага олж авах боломжтой гэдгийг илэрхийлж болох ба бусад байгууллагын зорилго ба бүтцийг тодорхойлох чадвар боломж нь бүрэн эрхийг үүсэхэд хүргэж болох юм. Үүсгэн байгуулах үед өөрийн ихэнх (буюу бүх) холбогдох үйл ажиллагааг урьдчилан тодорхойлсноор үүсгэн байгуулагдсан байгууллагын хувьд түүний зорилго ба бүтцийг тодорхойлох чадвар боломжтой байх нь өдөр тутмын аливаа шийдвэр гаргах эрхтэй харьцуулахад хяналтын үнэлгээтэй илүү их хамааралтай байж болох юм.

МЗУ54. Түүнчлэн, байгууллага нь уг бусад байгууллагыг үүсгэн байгуулах үед тогтоосон хууль тогтоох буюу засаглах бүрэн эрхээс үүсэх дуудах эрх, буцаах эрх, татан буулгах эрх гэх мэт заавал биелүүлэх хэлцлийн эрхүүдийг харгалзан үзнэ. Заавал биелүүлэх хэлцэл нь бусад байгууллагатай нягт холбоотой үйл ажиллагаануудыг хамардаг тохиолдолд хэдийгээр тэдгээр үйл ажиллагаа нь уг бусад байгууллагын хууль ёсны хил хязгаараас гадна явагдсан ч гэсэн мөн чанарын хувьд тухайн бусад байгууллагын ерөнхий үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг байна. Иймээс бусад байгууллагатай нягт холбоотой заавал биелүүлэх хэлцэлд тусгагдсан, шийдвэр гаргах шууд болон шууд бус эрхүүдийг уг бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй эсэхийг тодорхойлох үедээ холбогдох үйл ажиллагаа байдлаар харгалзан үзэх шаардлагатай.

МЗУ55. Зарим бусад байгууллагын хувьд, зөвхөн тодорхой нөхцөл байдал үүссэн эсвэл үйл явдал гарч тохиолдсон үед холбогдох үйл ажиллагаа явагддаг. Тухайн тодорхой нөхцөл байдал үүсэхгүй буюу үйл явдал гарч тохиолдохгүй бол, түүнчлэн тэдгээр нөхцөл байдал буюу үйл явдал гарч тохиолдох хүртэл түүний үйл ажиллагааны удирдан чиглүүлэлт ба тэдгээр үйл ажиллагааны өгөөжийг урьдчилан тодорхойлсон байхаар уг бусад байгууллагыг зохион байгуулсан байж болно. Энэ тохиолдолд тэдгээр нөхцөл байдал буюу үйл явдал зөвхөн гарч тохиолдох үед уг бусад байгууллагын үйл ажиллагааны талаархи шийдвэр нь бусад байгууллагын өгөөжид, иймээс холбогдох үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болох юм. Тэдгээр шийдвэрийг гаргах чадвар боломж бүхий байгууллагын хувьд бүрэн эрхтэй болохын тулд уг нөхцөл байдал буюу үйл явдал заавал гарч тохиолдсон байх албагүй юм. Шийдвэр гаргах эрх нь үүсэх нөхцөл байдал эсвэл гарч тохиолдох үйл явдлаас хамааран болзошгүй шинжтэй байгаа нь уг эрх хамгаалалтын эрх гэсэн утгыг илэрхийлэхгүй.

МЗУ56. Байгууллага нь төлөвлөн зохион байгуулсны дагуу уг бусад байгууллага үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна гэдгийг ханган магадлах шууд буюу шууд бус баталгаа гаргасан байж болно. Ийм баталгаа нь өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд байгууллагын хүлээх эрсдлийг нэмэгдүүлж болох бөгөөд ингэснээр түүнд бүрэн эрх олгох хангалттай эрхийг олж авах тухайн байгууллагын сэдэл санаачлагыг нэмэгдүүлдэг. Иймээс

төлөвлөн зохион байгуулсны дагуу уг бусад байгууллага үйл ажиллагаагаа явуулна гэдгийг ханган магадалсан баталгаа нь тухайн байгууллага бүрэн эрхтэй гэсэн шинж тэмдэг байж болох боловч энэ нь тэрхүү байгууллагад бүрэн эрхийг дангаараа олгохгүй, мөн өөр тал бүрэн эрхтэй байхыг хязгаарлан хориглохгүй.

**Бусад байгууллагын хувьсах өгөөжийн хувьд хүлээх эрсдэл эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрх**

МЗУ57. Байгууллага нь бусад байгууллагыг хянадаг эсэхийг үнэлэх үедээ тухайн байгууллага нь уг бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх хувьсах өгөөжийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй эсэхээ тодорхойлно.

МЗУ58. Хувьсах өгөөж гэдэг нь тогтмол биш бөгөөд бусад байгууллагын үйл ажиллагааны үр дүнгээс хамааран хувьсан өөрчлөгдөх боломжтой өгөөж юм. Хувьсах өгөөж нь зөвхөн эерэг, зөвхөн сөрөг эсвэл эерэг ба сөрөг байж болно (30-р параграфыг үзнэ үү). Бусад байгууллагаас авах өгөөж нь хувьсах эсэх, гэрээний тохиролцооны шинж чанараас хамааран тэрхүү өгөөж хэрхэн хувьсан өөрчлөгдөх бөгөөд өгөөжийн хуулийн хэлбэрээс хамааралгүй эсэхийг тухайн байгууллага нь үнэлнэ. Жишээлбэл:

- (а) Санхүүгийн бус өгөөжийн хүрээнд, байгууллага нь өөрийн зорилгоо хэрэгжүүлэхдээ бусад байгууллагын үйл ажиллагааны үр дүнд өгөөж хүртэж болно. Өгөөжийн хувьд байгууллага нь бусад байгууллагын гүйцэтгэлийн эрсдэлд өртөж болох учраас уг өгөөж нь энэхүү Стандартын зорилгын хувьд хувьсан өөрчлөгдөх өгөөж байж болох юм. Хэрэв бусад байгууллага нь эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэх боломжгүй байсан бол тухайн байгууллага нь үйл ажиллагааг өөрөө гүйцэтгэснээр, эсвэл тэдгээр үйл ажиллагааг үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжийг уг бусад байгууллагад олгохын тулд нэмэлт мөнгө сан буюу бусад хэлбэрийн тусалцаа үзүүлснээр нэмэлт зардал гаргаж болох юм.
- (б) Санхүүгийн өгөөжийн хүрээнд, байгууллага нь тогтмол хүүний төлбөр бүхий бондыг эзэмшдэг байж болно. Тогтмол хүүний төлбөр нь үл биелүүлэлтийн эрсдэлд өртдөг бөгөөд тухайн байгууллага нь уг бонд гаргагчийн хувьд зээлийн эрсдэл хүлээдэг учраас энэхүү Стандартын зорилгын хувьд тогтмол хүүний төлбөр нь хувьсах өгөөж юм. Хувьсан өөрчлөлтийн дүн (өөрөөр хэлбэл, тэрхүү өгөөж хэр хувьсах эсэх) нь уг бондын зээлийн эрсдлээс хамаардаг. Үүнтэй адилаар, бусад байгууллагын хөрөнгийг удирдан зохицуулсаны төлөөх үр дүнгийн тогтмол хөлс нь хувьсах өгөөж болно. Яагаад гэвэл, байгууллага нь уг бусад байгууллагын үйл ажиллагааны хувьд эрсдэл хүлээж байдаг. Хувьсан өөрчлөлтийн дүн нь тэрхүү хөлсийг төлөх хангалттай орлого бий болгох уг бусад байгууллагын чадвар, боломжоос хамаардаг.

МЗУ59. Татан буулгагч нь уг татан буугдаж буй байгууллага дахь өөрийн оролцооноос ихэвчлэн хувьсах өгөөж хүртэх эрхгүй байдаг.

## Бүрэн эрх ба өгөөжийн хоорондох холбоо

### Төлөөлсөн бүрэн эрх

МЗУ60. Улсын секторын байгууллагууд нь засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээх нь нийтлэг байдаг. Зарим тохиолдолд тэд өөрийн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах бүрэн эрхтэй, өөр зарим тохиолдолд Сайд буюу өөр байгууллагын төлөөлөгч байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг байж болно. Жишээлбэл:

- (а) Сайдын нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэх бүрэн эрхийг Сайдаас хүлээн авсан Засгийн газрын газар хэлтэс нь уг хариуцсан Сайдын зөвхөн төлөөлөгчийн үүргийг бусад байгууллагын хувьд гүйцэтгэж болох юм. Ийм тохиолдолд тухайн газар хэлтэс нь бусад байгууллагад хяналт тавихгүй ба түүнийг нэгтгэхгүй.
- (б) Засгийн газрын газар хэлтэс нь Сайдаас олгосон бүрэн эрхийн төлөөллийн дагуу үйл ажиллагаагаа явуулж болно. Ийм газар хэлтэс нь шийдвэр гаргах ба арга хэмжээг хэрэгжүүлэхдээ өөрийн бүрэн эрхийг ашиглах бөгөөд Сайдаас удирдамж чиглэл авдаггүй. Энэ тохиолдолд тухайн газар хэлтэс нь өөрийн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд бусад байгууллагыг хянадаг эсэхээ тодорхойлохын тулд энэхүү Стандартын бусад шаардлагуудыг мөрдөх шаардлагатай юм. Бусад байгууллагын хувьд шийдвэр гаргах тус газар хэлтсийн бүрэн эрхийн цар хүрээ нь тэрээр төлөөлөн оролцогчийн эсвэл үндсэн оролцогчийн үүрэг гүйцэтгэж буй эсэхийг ялган тодорхойлоход чухал ач холбогдолтой хүчин зүйл юм.
- (в) Байгууллага нь тусгайлан заасан үйл ажиллагааг гүйцэтгэх итгэмжлэгдсэн байгууллагыг байгуулж, итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилж болно. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь уг итгэмжлэгдсэн байгууллагын санхүүжилтийн үндсэн үйл ажиллагааны талаархи шийдвэрийг итгэмжлэлийн гэрээний дагуу гаргах хариуцлага хүлээдэг. Хэрэв тухайн байгууллага нь өөрийн эрхийн хүрээнд итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сольж өөрчилж чаддаг бол тус байгууллага нь тухайлбал, уг итгэмжлэгдсэн байгууллагын үйл ажиллагаагаар дамжин өөрийн зорилтууд хангагддаг буюу түүнд дөхөм үзүүлдэг хэмжээгээр хувьсах өгөөжийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл ийм өгөөжийг хүртэх эрхтэй гэдгээ харгалзан үзсэнээр тэрхүү итгэмжлэгдсэн байгууллагыг хянадаг эсэхээ үнэлэх шаардлагатай юм.

МЗУ61. Байгууллага нь зарим тусгай асуудлын эсвэл бүх холбогдох үйл ажиллагааны талаархи өөрийн шийдвэр гаргах бүрэн эрхийг төлөөлөн оролцогчид шилжүүлэн төлөөлүүлж болно. Бусад байгууллагыг хянадаг эсэхээ үнэлэх үедээ, тухайн байгууллага нь өөрийн төлөөлөн оролцогчид шилжүүлэн төлөөлүүлсэн уг шийдвэр гаргах эрхээ өөрөө шууд эзэмшиж байгаа мэтээр харгалзан үзнэ. Нэгээс олон үндсэн оролцогчтой тохиолдолд, оролцогч бүр нь МЗУ5-МЗУ56-р параграфт заасан

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

шаардлагуудыг харгалзан үзсэнээр уг бусад байгууллагын хувьд өөрөө бүрэн эрхтэй эсэхээ үнэлдэг. Шийдвэр гаргагч нь төлөөлөн оролцогч эсвэл үндсэн оролцогч эсэхийг тодорхойлох талаархи заавар удирдамжийг МЗУ62-МЗУ74-р параграфт тусгасан.

МЗУ62. Өөрийгөө төлөөлөн оролцогч эсэхийг тодорхойлох үедээ тухайн шийдвэр гаргагч нь өөрөө, түүнчлэн өөрийн удирдан зохицуулж буй бусад байгууллага, тэрхүү бусад байгууллагад оролцоотой бусад талуудын хоорондох ерөнхий харилцааг харгалзан үзнэ. Ялангуяа шийдвэр гаргагч нь өөрөө төлөөлөн оролцогч эсэхийг тодорхойлохдоо дараах бүх хүчин зүйлсийг харгалзан үзнэ:

- (а) Уг бусад байгууллагын талаар шийдвэр гаргах өөрийн эрхийн цар хүрээ (МЗУ64, МЗУ65-р параграф);
- (б) Бусад талуудын эзэмшиж буй эрхүүд (МЗУ66-МЗУ69-р параграф);
- (в) Урамшууллын гэрээний дагуу түүнд олгох урамшуулал (МЗУ70-МЗУ72-р параграф); ба
- (г) Бусад байгууллага дахь өөрийн эзэмшиж буй бусад хувь оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд тухайн шийдвэр гаргагчийн хүлээх эрсдэл (МЗУ73, МЗУ74-р параграф).

Тухайн тодорхой баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн эдгээр хүчин зүйлс тус бүрд харилцан адилгүй ач холбогдол өгнө.

МЗУ63. Зөвхөн нэг тал нь шийдвэр гаргагчийг цуцлах бодит эрхийг (цуцлах эрхийг) эзэмшдэг бөгөөд шалтгаан заахгүйгээр уг шийдвэр гаргагчийг сольж өөрчилж чадахаас бусад тохиолдолд (МЗУ67-р параграфыг үзнэ үү) шийдвэр гаргагч нь төлөөлөн оролцогч эсэхийг тодорхойлохдоо МЗУ62-р параграфт жагсаан харуулсан бүх хүчин зүйлсийн үнэлгээ хийх шаардлагатай байдаг.

Шийдвэр гаргах эрхийн цар хүрээ

МЗУ64. Шийдвэр гаргагчийн шийдвэр гаргах эрхийн цар хүрээг дараах зүйлсийг харгалзан үзсэнээр үнэлнэ:

- (а) Шийдвэр гаргах талаархи гэрээгээр зөвшөөрсөн ба хуульд тусгайлан заасан үйл ажиллагаа, ба
- (б) Тэдгээр үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах тухайн шийдвэр гаргагчийн эрх мэдэл.

МЗУ65. Шийдвэр гаргагч нь бусад байгууллагын зорилго ба бүтэц, уг бусад байгууллагад учрах эрсдэл, бусад байгууллагын хувьд оролцоотой талуудад шилжүүлэх эрсдэл, бусад байгууллагын бүтэц дэх шийдвэр гаргагчийн өөрийн оролцооны түвшинг харгалзан үзнэ. Тухайлбал; шийдвэр гаргагч нь бусад байгууллагын бүтцэд (үүн дотроо, шийдвэр гаргах эрхийн цар хүрээг тодорхойлоход) мэдэгдэхүйц оролцдог бол тухайн шийдвэр гаргагч нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

чадвар, боломжийг түүнд бий болгох эрхийг олж авах боломж ба сэдэл санаачлагатай байсан гэдгийг тэрхүү оролцоо илэрхийлж болох юм.

Бусад талуудын эзэмшиж буй эрх

- МЗУ66. Бусад талуудын эзэмшиж буй бодит эрх нь бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх тухайн шийдвэр гаргагчийн чадвар, боломжид нөлөөлж болно. Цуцлах буюу бусад бодит эрх нь уг шийдвэр гаргагч төлөөлөн оролцогч гэдгийг илэрхийлж болох юм.
- МЗУ67. Зөвхөн нэг тал нь цуцлах бодит эрхийг эзэмшдэг бөгөөд шалтгаан заахгүйгээр уг шийдвэр гаргагчийг сольж өөрчилж чадах тохиолдолд шийдвэр гаргагч нь төлөөлөн оролцогч гэж дүгнэхэд энэ нь дангаараа хангалттай юм. Хэрэв ийм эрхийг нэгээс олон оролцогч тал эзэмшдэг (ба аль нэг тал нь бусад талуудтай тохирохгүйгээр уг шийдвэр гаргагчийг сольж өөрчилж чадахгүй) бол тэрхүү шийдвэр гаргагчийг бусдын нэрийн өмнөөс болон тэдний эрх ашгийн төлөө юуны өмнө үүрэг гүйцэтгэдэг гэж тодорхойлоход тухайн эрх нь дангаараа дүгнэлтийн шинжтэй болж чадахгүй. Үүнээс гадна шийдвэр гаргагчийг халж солих эрхийг хэрэгжүүлэхийн тулд хамтран санал гаргах талуудын тоо хичнээн олон байх тусам, түүнчлэн тухайн шийдвэр гаргагчийн эдийн засгийн бусад хувь оролцоо (өөрөөр хэлбэл, шагнал урамшуулал ба бусад хувь оролцоо) болон холбогдох хувьсан өөрчлөлтийн ач холбогдол хичнээн их байх тусам энэхүү эрх гэсэн хүчин зүйлд өгөх хувийн жин төдий чинээ бага байна.
- МЗУ68. Шийдвэр гаргагч нь төлөөлөн оролцогч эсэхийг үнэлэх тохиолдолд бусад талуудын эзэмшиж байгаа бөгөөд уг шийдвэр гаргагчийн эрх мэдлийг хязгаарлах бодит эрхүүдийг цуцлах эрхтэй ижил арга замаар харгалзан үзнэ. Тухайлбал; өөрийн үйл ажиллагааг явуулахын тулд цөөн тооны бусад талуудаас зөвшөөрөл олж авах шаардлагатай шийдвэр гаргагч нь ерөнхийдөө төлөөлөн оролцогч байдаг. (Эрх, түүнчлэн тэдгээр эрх нь бодит эсэх талаархи нэмэлт заавар удирдамжийг МЗУ25-МЗУ28-р параграфтаас үзнэ үү).
- МЗУ69. Бусад талуудын эзэмшиж буй эрхийн талаархи хэлэлцүүлэг нь бусад байгууллагын захирлуудын зөвлөл (буюу бусад эрх бүхий байгууллага)-ийн хэрэгжүүлж болох аливаа эрх, түүнчлэн шийдвэр гаргах бүрэн эрхэд тэдгээрийн үзүүлэх үр нөлөөний (МЗУ26(б) параграфыг үзнэ үү) талаархи үнэлгээг агуулсан байдаг.

Шагнал урамшуулал

- МЗУ70. Бусад байгууллагын үйл ажиллагаанаас бий болохоор хүлээгдэж буй өгөөжтэй харьцуулахад шийдвэр гаргагчийн шагнал урамшуулал болон тэдгээрийн холбогдох хувьсан өөрчлөлтийн ач холбогдол хичнээн их байх тусам тухайн шийдвэр гаргагч нь үндсэн оролцогч байх магадлал төдий чинээ их байна.

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- МЗУ71. Өөрөө үндсэн оролцогч эсвэл төлөөлөн оролцогч эсэхээ тодорхойлохын тулд шийдвэр гаргагч нь холбоогүй талуудын ажил гүйлгээгээр хэлэлцэн тохирдогтой ижил төсөөтэй үйлчилгээ ба ур чадварын түвшний хувьд хэлцэлд нийтлэг тусгагдах зөвхөн тийм нөхцөл, болзол буюу дүнг уг шагнал урамшууллын гэрээнд тусган агуулсан эсэхийг мөн харгалзан үзнэ.
- МЗУ72. МЗУ74(а) ба (б) параграфт заасан нөхцлүүд хангагдахаас бусад тохиолдолд шийдвэр гаргагч нь төлөөлөн оролцогч биш байна. Гэвч эдгээр нөхцлүүдийг хангах нь тухайн шийдвэр гаргагч төлөөлөн оролцогч гэж дүгнэхэд дангаараа хангалтгүй юм.

Бусад хувь оролцооноос бий болох өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд хүлээх эрсдэл

- МЗУ73. Бусад байгууллагад өөр бусад хувь оролцоог эзэмшиж буй шийдвэр гаргагч (жишээлбэл; бусад байгууллагад оруулсан хөрөнгө оруулалт эсвэл бусад байгууллагын үйл ажиллагааны талаар баталгаа гаргаж өгсөн) нь өөрөө төлөөлөн оролцогч эсэхээ үнэлэх үедээ тэдгээр хувь оролцооноос бий болох өгөөжийн хувьсан өөрчлөлтийн эрсдлийг харгалзан үзнэ. Бусад байгууллагад бусад хувь оролцоотой байгаа нь тухайн шийдвэр гаргагч үндсэн оролцогч гэдгийг илэрхийлж болох юм.
- МЗУ74. Бусад байгууллага дахь бусад хувь оролцооноос бий болох өгөөжийн хувьсан өөрчлөлтийн эрсдлийг үнэлэх үедээ шийдвэр гаргагч нь дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- (а) Өөрийн шагнал урамшуулал болон бусад хувь оролцоог нийтэд нь авч үзэхэд, түүний эдийн засгийн хувь оролцоо болон холбогдох хувьсан өөрчлөлтийн ач холбогдол хичнээн их байх тусам уг шийдвэр гаргагч нь үндсэн оролцогч байх магадлал төдий чинээ их байна.
- (б) Өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд хүлээх түүний эрсдэл нь хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллагаас өгөөж хүртэх бусад байгууллагуудын эрсдлээс өөр эсэх, хэрэв өөр бол энэ нь түүний үйл ажиллагаанд нөлөөлж болох эсэх. Тухайлбал; шийдвэр гаргагч нь бусад байгууллагад тэргүүн бус ээлжийн хувь оролцоотой эсвэл түүнд бусад хэлбэрээр зээлийн сайжруулалт хийдэг бол ийм тохиолдол үүсэж болох юм.

Шийдвэр гаргагч нь бусад байгууллагын өгөөжийн нийт хувьсан өөрчлөлттэй харьцуулан өөрийн эрсдлийг үнэлнэ. Энэхүү үнэлгээ нь юуны өмнө бусад байгууллагын үйл ажиллагаанаас хүлээгдэж буй өгөөжид үндэслэдэг боловч шийдвэр гаргагчийн эзэмшиж буй бусад хувь оролцооны улмаас уг бусад байгууллагын өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд тухайн шийдвэр гаргагчийн хүлээх хамгийн их эрсдлийг харгалзахгүй байж болохгүй юм.

**Бусад талуудтай холбогдох харилцаа**

- МЗУ75. Хяналтыг үнэлэх үедээ тухайн байгууллага нь бусад талуудтай өөрийн холбогдох харилцааны шинж төрөл болон тэдгээр бусад талууд түүний нэрийн өмнөөс ажиллаж буй (өөрөөр хэлбэл, 'жинхэнэ төлөөлөн оролцогч') эсэхийг харгалзан үзнэ. Бусад талууд жинхэнэ төлөөлөн оролцогчийн үүрэг гүйцэтгэж буй эсэх тодорхойлолт нь зөвхөн тухайн харилцааны шинж төрөл төдийгүй тэдгээр талууд нь өөр хоорондоо болон уг байгууллагатай хэрхэн харилцдагийг харгалзан үзсэнээр шүүн тунгаалт хийхийг шаарддаг.
- МЗУ76. Ийм харилцаа нь заавал биелүүлэх хэлцэл байх албагүй юм. Ийм харилцаа нь заавал биелүүлэх хэлцлийн тодорхойлолтыг хангахгүй хууль тогтоох буюу засаглах бүрэн эрхээс бас үүсэж болох юм. Байгууллага эсвэл түүний үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг этгээд нь тухайн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг талыг удирдан чиглүүлэх чадвар, боломжтой тохиолдолд тэрхүү тал нь жинхэнэ төлөөлөн оролцогч болно. Энэ тохиолдолд бусад байгууллагын хяналтыг үнэлэхдээ, тухайн байгууллага нь төлөөлөн оролцогчийн шийдвэр гаргах эрх, түүнчлэн өөрөөс болон уг жинхэнэ төлөөлөн оролцогчоос хамаарах өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд хүлээх эрсдэл эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхийг харгалзан үзнэ.
- МЗУ77. Холбогдох харилцааны шинж төрлийн дагуу тухайн байгууллагын жинхэнэ төлөөлөн оролцогчийн үүрэг гүйцэтгэж болох ийм бусад талуудын жишээнд дараах талууд хамаарна:
- (а) Тухайн байгууллагын холбоотой талууд.
  - (б) Бусад байгууллага дахь өөрийн хувь оролцоог хяналтын үнэлгээ хийж буй тухайн байгууллагаас хувь нийлүүлэлт буюу зээл хэлбэрээр хүлээн авдаг тал.
  - (в) Бусад байгууллага дахь өөрийн хувь оролцоогоо тухайн байгууллагын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр худалдах, шилжүүлэх буюу барьцаалахгүй байхаар зөвшөөрсөн тал (тухайн байгууллага болон уг бусад тал нь урьдчилсан зөвшөөрөл авах эрхтэй бөгөөд тэрхүү эрх нь арилжаанд оролцоход бэлэн байгаа, хараат бус талуудын хамтран тохиролцсон нөхцөлд үндэслэдэг байхаас бусад тохиолдолд).
  - (г) Тэргүүн бус ээлжийн эрхтэй санхүүгийн дэмжлэгийг тухайн байгууллагаас авахгүйгээр өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлж чадахгүй тал.
  - (д) Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи эсвэл эрх бүхий албан тушаалтан нь тухайн байгууллагын тийм албан тушаалын хүмүүс байх бусад байгууллага.

- (е) Тухайн байгууллагатай бизнесийн нягт харилцаа холбоо бүхий тал. Жишээлбэл; мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч болон түүний гол үйлчлүүлэгчийн хоорондох харилцаа гэх мэт.

**Тусгайлан заасан хөрөнгийн хяналт**

МЗУ78. Тухайн байгууллага нь бусад байгууллагын тодорхой нэг хэсгийг төсөөлөн тооцсон тусдаа байгууллага гэж үзэх эсэх, хэрэв тийм бол уг төсөөлөн тооцсон тусдаа байгууллагыг хянадаг эсэхээ харгалзан үзнэ.

МЗУ79. Дараах нөхцөл хангагдсан бол, зөвхөн тийм тохиолдолд тухайн байгууллага нь бусад байгууллагын тодорхой нэг хэсгийг төсөөлөн тооцсон тусдаа байгууллага гэж үзнэ:

- Бусад байгууллагын тусгайлан заасан хөрөнгүүд (болон хэрэв байгаа бол холбогдох зээлийн сайжруулалтууд) нь уг бусад байгууллагын тусгайлан заасан өр төлбөр буюу тусгайлан заасан бусад хувь оролцооны төлбөрийн цорын ганц эх үүсвэр байх. Уг тусгайлан заасан өр төлбөр бүхий талуудаас бусад талууд нь тэрхүү тусгайлан заасан хөрөнгө болон тэдгээр хөрөнгөөс үүссэн үлдэх мөнгөн гүйлгээтэй холбоотойгоор эрх буюу үүрэггүй байна. Мөн чанарын хувьд, уг тусгайлан заасан хөрөнгөөс үүсэх өгөөжийг бусад байгууллага ашиглаж болохгүй ба тэрхүү төсөөлөн тооцсон тусдаа байгууллагын өр төлбөрийг бусад байгууллагын хөрөнгөөр төлөхгүй. Иймээс мөн чанарын хувьд, уг төсөөлөн тооцсон тусдаа байгууллагын бүх хөрөнгө, өр төлбөр, өмч нь ерөнхийдөө тэрхүү бусад байгууллагаас зааглагдан тусгаарлагдсан байна. Ийм төсөөлөн тооцсон тусдаа байгууллагыг ихэвчлэн 'нөөц агуулах' гэж нэрлэдэг.

МЗУ80. МЗУ79-р параграфт заасан нөхцөл хангагдсан тохиолдолд байгууллага нь уг төсөөлөн тооцсон тусдаа байгууллагын өгөөжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үйл ажиллагаа, түүнчлэн бусад байгууллагын тэрхүү тодорхой хэсгийн хувьд бүрэн эрхтэй эсэхээ үнэлэхийн тулд эдгээр үйл ажиллагааг хэрхэн удирдан чиглүүлдэг болохыг тодорхойлно. Төсөөлөн тооцсон тусдаа байгууллагын хяналтыг үнэлэх үедээ тухайн байгууллага нь уг төсөөлөн тооцсон тусдаа байгууллага дахь түүний оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээх эсвэл өгөөжийг авах эрхтэй эсэх, түүнчлэн өөрийн өгөөжийн дүнд нөлөөлөхийн тулд бусад байгууллагын тэрхүү тодорхой хэсэг дэх бүрэн эрхээ ашиглах чадвар, боломжтой эсэхээ бас харгалзан үзнэ.

МЗУ81. Хэрэв байгууллага нь уг төсөөлөн тооцсон тусдаа байгууллагыг хянадаг бол тухайн байгууллага нь бусад байгууллагын тэрхүү тодорхой хэсгийг нэгтгэнэ. Энэ тохиолдолд өөр бусад талууд нь бусад байгууллагын хяналтыг үнэлэх ба түүнийг нэгтгэх үедээ уг бусад байгууллагын тэрхүү тодорхой хэсгийг харгалзан үзэхгүй.



**Байнгын үнэлгээ**

- МЗУ82. Хэрэв баримт материал ба нөхцөл байдал нь 20-р параграфт жагсаан харуулсан хяналтын гурван элементийн нэг буюу хэд хэдэн элементэд өөрчлөлт орсон гэдгийг илэрхийлж байвал тухайн байгууллага нь уг бусад байгууллагыг хянадаг эсэхээ дахин үнэлнэ.
- МЗУ83. Хэрэв бусад байгууллага дахь бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх эсэхэд өөрчлөлт орсон бол байгууллага нь уг бусад байгууллага дахь өөрийн бүрэн эрхийг үнэлэхдээ тэрхүү өөрчлөлтийг харгалзан тусгах ёстой. Жишээлбэл; шийдвэр гаргах эрхийн өөрчлөлт нь холбогдох үйл ажиллагааг цаашид саналын эрхээр дамжуулан удирдан чиглүүлэхгүй, харин тухайн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг өөр нэг тал буюу талуудад олгосон гэрээ гэх мэт бусад тохиролцоогоор удирдан чиглүүлнэ гэсэн утгыг илэрхийлж болох юм.
- МЗУ84. Тодорхой нэг үйл явдалд байгууллага оролцоогүй боловч тэрхүү үйл явдал нь бусад байгууллага дахь бүрэн эрхийг тухайн байгууллага олж авах эсвэл алдахад хүргэж болно. Тухайлбал; бусад байгууллагыг тухайн байгууллага хянахад өмнө нь саад учруулж байсан, өөр нэг буюу хэд хэдэн талуудын эзэмшиж байсан шийдвэр гаргах эрхийн хугацаа дууссаны үр дүнд байгууллага нь бусад байгууллагын бүрэн эрхийг олж авч болно.
- МЗУ85. Бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд түүний хүлээх эрсдэл эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхэд нөлөө үзүүлэх өөрчлөлтүүдийг тухайн байгууллага нь мөн харгалзан үзнэ. Тухайлбал; байгууллага нь 20(б) параграфт заасан шалгуурыг хангахгүй болсоны (жишээлбэл; үр дүнд үндэслэн хөлс авах гэрээ цуцлагдсан) улмаас байгууллага нь өгөөжийг хүлээн авах эрх эсвэл үүргийг хариуцах эрсдэл дуусгавар болсон тохиолдолд бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй байсан тухайн байгууллага нь уг бусад байгууллага дахь хяналтаа алддаг.
- МЗУ86. Төлөөлөн оролцогчийн эсвэл үндсэн оролцогчийн үүрэг гүйцэтгэдэг эсэх талаархи түүний үнэлгээ өөрчлөгдсөн эсэхийг тухайн байгууллага нь харгалзан үзнэ. Тухайн байгууллага болон бусад талуудын хоорондох ерөнхий харилцааны өөрчлөлт нь хэдийгээр уг байгууллага өмнө нь төлөөлөн оролцогчийн үүрэг гүйцэтгэж байсан боловч цаашид төлөөлөн оролцогчийн үүрэг гүйцэтгэхгүй гэдгийг илэрхийлж болно. Мөн эсрэгээр, үндсэн оролцогчийн үүрэг гүйцэтгэж байсан боловч цаашид үндсэн оролцогчийн үүрэг гүйцэтгэхгүй гэдгийг илэрхийлж болно. Тухайлбал; тухайн байгууллагын эсвэл бусад талуудын эрхэд өөрчлөлт орсон бол тэрхүү байгууллага нь үндсэн оролцогч эсвэл төлөөлөн оролцогч эсэх өөрийн статусыг дахин авч үзнэ.
- МЗУ87. Зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлт нь 20-р параграфт жагсаан харуулсан хяналтын гурван элементийн нэг буюу хэд хэдэн элементэд

өөрчлөлт оруулсан эсвэл үндсэн оролцогч ба төлөөлөн оролцогчийн хоорондох ерөнхий харилцаанд өөрчлөлт оруулснаас бусад тохиолдолд хяналтын, түүнчлэн үндсэн оролцогч эсвэл төлөөлөн оролцогч эсэх өөрийн статусын талаархи тухайн байгууллагын анхны үнэлгээ нь зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс (жишээлбэл; зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалсан уг бусад байгууллагын өгөөжийн өөрчлөлтөөс) хамааран шууд өөрчлөгдөөд байдаггүй.

### **Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага эсэхийг тодорхойлох**

МЗУ88. Байгууллага нь өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага эсэхийг үнэлэхдээ бүх баримт материал болон нөхцөл байдлуудыг, үүн дотроо өөрийн зорилго ба бүтцийг харгалзан үзнэ. МЗУ89-МЗУ106-р параграфт хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтын төлөв байдлуудыг илүү дэлгэрэнгүй тайлбарласан.

### **Олон хөрөнгө оруулагчид**

МЗУ89. Хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолт нь тухайн байгууллага нэг буюу хэд хэдэн хөрөнгө оруулагчидтай байхыг шаарддаг. Хөрөнгө оруулалтын байгууллага нь тус тусдаа авч чадахааргүй байсан хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын боломжуудыг олж авахын тулд өөрсдийн мөнгө санг нийлүүлсэн хэд хэдэн хөрөнгө оруулагчидтай байж болно. Хэд хэдэн хөрөнгө оруулагчидтай байх нь капиталын үнийн өсөлт эсвэл хөрөнгө оруулалтын орлогоос өөр бусад өгөөжийг тухайн байгууллага болон түүнийг агуулсан эдийн засгийн нэгдмэл байгууллагын бусад гишүүд хүртэх магадлалыг бууруулдаг.

МЗУ90. Нөгөө талаас, хөрөнгө оруулагчдын өргөн хүрээтэй бүлгийн (жишээлбэл; тэтгэврийн сан, засгийн газрын хөрөнгө оруулалтын сан, итгэлцлийн сан) ашиг сонирхолыг төлөөлөх буюу түүнд дэмжлэг үзүүлэх нэг хяналт тавигч байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагыг үүсгэн байгуулах нь улсын секторт мөн нийтлэг байдаг.

### **Өмчлөлийн хувь оролцоо**

МЗУ91. Хөрөнгө оруулалтын байгууллага нь ихэвчлэн тусдаа хуулийн этгээд байдаг боловч ийм байхыг заавал шаардахгүй. Хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулагчид нь байнга биш гэхэд ихэвчлэн тухайн хөрөнгө оруулалтын байгууллагын цэвэр хөрөнгийн хувь тэнцүүлсэн хэсэгт хамаарах өмч буюу ижил төсөөтэй хувь оролцоо (жишээлбэл; нөхөрлөлийн хувь оролцоо) хэлбэртэй өмчлөлийн хувь оролцоотой байдаг. Хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолт нь бүх хөрөнгө оруулагчид ижил эрхтэй байх ёстой гэж заагаагүй. Хөрөнгө оруулагчдын янз бүрийн ангиудтай, тэдгээрийн зарим нь зөвхөн тодорхой хөрөнгө оруулалт буюу хөрөнгө оруулалтын бүлгийн хувьд эрхтэй эсвэл цэвэр хөрөнгөнд өөр өөр хувь тэнцүүлсэн оролцоотой байх нь тухайн байгууллага хөрөнгө оруулалтын байгууллага болоход саад учруулахгүй.

МЗУ92. Хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолт нь хөрөнгө оруулагч нар бусад холбогдох УСНББОУС-уудын дагуу цэвэр хөрөнгө/өмчийн тодорхойлолтыг хангасан өмчлөлийн хувь оролцоотой байх ёстой гэж тусгайлан заагаагүй. Хэрэв өрийн эзэмшигчид нь тухайн байгууллагын цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэлд өртдөг бол цэвэр хөрөнгө/өмчийн тодорхойлолтыг хангахгүй өр хэлбэрээр өмчлөлийн мэдэгдэхүйц хувь оролцоотой байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага болох шалгуурыг хангасан хэвээр байж болно.

### **Зорилго**

МЗУ93. Хөрөнгө оруулалтын байгууллагын зорилго нь капиталын үнийн өсөлт, хөрөнгө оруулалтын орлого (ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, хүүний орлого, түрээсийн орлого гэх мэт) эсвэл энэ хоёрын аль алианаас ашиг олох зорилгоор хөрөнгө оруулалт хийх явдал гэдгийг хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтонд зааж, шаардсан байдаг. Байгууллагын эрхийн бичиг, дүрэм, үнэт цаас санал болгох санамж бичиг, уг байгууллагаас гаргаж, хэвлэн нийтэлсэн материал, корпорацийн буюу нөхөрлөлийн бусад баримт бичиг гэх мэт тухайн байгууллагын хөрөнгө оруулалтын зорилгыг заасан баримт бичгүүд нь хөрөнгө оруулалтын байгууллагын зорилгын талаархи нотолгоогоор ихэвчлэн хангадаг. Байгууллага нь бусад талуудад өөрийгөө илэрхийлж буй арга хэлбэр нь нэмэлт нотолгоонд хамаарч болох юм. Тухайлбал; байгууллага нь капитал үнийн өсөлтөөс ашиг олохын тулд дунд хугацааны хөрөнгө оруулалт хийдэг гэж өөрийн зорилгыг илэрхийлдэг байж болно.

МЗУ94. Хөрөнгө оруулалтын байгууллагын зорилготой нийцэхгүй нэмэлт зорилго бүхий байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг хангахгүй. Ийм тохиолдол үүсэж болох жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Санхүүжигчдийн хамт бүтээгдэхүүнийг хамтран боловсруулах, үйлдвэрлэх буюу зах зээлд гаргах гол зорилго бүхий хөрөнгө оруулагч. Ийм байгууллага нь хөгжүүлэлт, үйлдвэрлэл буюу маркетингийн үйл ажиллагаанаас, түүнчлэн өөрийн оруулсан хөрөнгө оруулалтаас өгөөж хүртдэг;
- (б) Бусад байгууллагын эдийн засгийн, нийгмийн болон байгаль орчны бодлоготой уялдсан байхыг шаарддаг тийм зорилго бүхий хөрөнгө оруулагч. Жишээлбэл; байгууллага нь тухайн улсад тодорхой бизнесийг өмчлөх эсвэл ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх гэх мэт өөр бусад зорилготой өөрийн хөрөнгө оруулалтын бодлогыг уялдуулах шаардлагатай тохиолдолд; ба
- (в) Хөрөнгө оруулалтын шийдвэр бүрийг хяналт тавигч байгууллагын зүгээс зөвшөөрөх буюу батлах шаардлагатай, эсвэл хяналт тавигч байгууллагын чиглэл удирдамжийг дагаж мөрдөх шаардлагатай хөрөнгө оруулагч. Ийм зөвшөөрөл, баталгаажуулалт, шийдвэр нь тухайн хөрөнгө оруулалтын байгууллагын зорилготой нийцэхгүй байх магадлалтай юм.

МЗУ95. Хөрөнгө оруулалтын байгууллагын зорилго нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж болох юм. Хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг үргэлжлүүлэн хангаж буй эсэхээ үнэлэхдээ, тухайн байгууллага нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй орчны аливаа өөрчлөлт, түүний хөрөнгө оруулалтын стратегид ийм өөрчлөлтийн үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.

*Нэгээс олон хөрөнгө оруулалтын эзэмшилтээр зорилгыг илэрхийлэх*

МЗУ96. Хөрөнгө оруулалтын байгууллага нь түүний зорилго бол капиталын үнийн өсөлт, хөрөнгө оруулалтын орлого эсвэл эдгээрийн аль алины төлөө мөнгө сангаар хөрөнгө оруулах явдал гэдгийг батлан илэрхийлэх олон арга замтай байж болно. Үүний нэг арга зам нь өөрийн эрсдлийг тараах ба өгөөжийг хамгийн их болгохын тулд хэд хэдэн хөрөнгө оруулалтыг эзэмших явдал юм. Байгууллага нь хөрөнгө оруулалтын багцыг шууд эсвэл шууд бусаар эзэмшиж болно. Тухайлбал; хэд хэдэн хөрөнгө оруулалтыг эзэмшдэг өөр нэг хөрөнгө оруулалтын байгууллагад зөвхөн нэг хөрөнгө оруулалт эзэмших байдлаар шууд бусаар эзэмшиж болно.

МЗУ97. Байгууллага нь ганцхан хөрөнгө оруулалт эзэмшдэг тийм тохиолдол зарим үед байдаг. Гэвч ганцхан хөрөнгө оруулалт эзэмших нь хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг тухайн байгууллага хангахад саад учруулах албагүй юм. Тухайлбал; дараах тохиолдолд хөрөнгө оруулалтын байгууллага нь ердөө ганц хөрөнгө оруулалт эзэмшдэг байж болно:

- (а) Байгууллага нь үйл ажиллагааны эхлэлийн шатандаа байгаа бөгөөд тохирох хөрөнгө оруулалтуудыг хараахан олоогүй, иймээс хэд хэдэн хөрөнгө оруулалтыг олж эзэмших өөрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хараахан хэрэгжүүлээгүй байгаа;
- (б) Данснаас хассан хөрөнгө оруулалтуудыг орлох өөр хөрөнгө оруулалтыг хараахан хийгээгүй байгаа;
- (в) Хөрөнгө оруулагч нар тус тусдаа худалдан авч чадахааргүй (жишээлбэл; шаардлагатай хамгийн бага хөрөнгө оруулалт нь тухайн нэг хөрөнгө оруулагчийн хувьд хэт өндөр дүнтэй байх) нэг том хөрөнгө оруулалтыг хийхийн тулд хөрөнгө оруулагчдын санг үүсгэхээр уг байгууллагыг үүсгэн байгуулсан; ба
- (г) Тухайн аж ахуйн нэгж нь татан буугдах гэж байгаа.

*Хөрөнгө оруулалттай холбоотой үйлчилгээ ба үйл ажиллагаа*

МЗУ98. Хөрөнгө оруулалтын байгууллага нь шууд эсвэл өөрийн хяналтанд буй байгууллагаар дамжуулан хөрөнгө оруулалттай холбоотой үйлчилгээг (жишээлбэл; хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх үйлчилгээ, хөрөнгө оруулалтын менежмент, хөрөнгө оруулалтын дэмжлэгийн болон удирдлагын үйлчилгээг) гуравдагч талд, түүнчлэн өөрийн хяналт тавигч байгууллагад, бусад хөрөнгө оруулагчдад үзүүлж болох бөгөөд тэдгээр үйл ажиллагаа нь уг байгууллагын хувьд мэдэгдэхүйц хэмжээтэй байлаа

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ч гэсэн тухайн байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг хангасан хэвээр байна.

МЗУ99. Хөрөнгө оруулалтын байгууллага нь өөрийн санхүүжигчээс олох хөрөнгө оруулалтын өгөөжийг (капиталын үнийн өсөлт эсвэл хөрөнгө оруулалтын орлогыг) нэмэгдүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд тэдгээр үйл ажиллагаа нь томоохон тусдаа үйл ажиллагааг илэрхийлдэггүй эсвэл уг хөрөнгө оруулалтын байгууллагын орлогын томоохон тусдаа эх үүсвэр болдоггүй бол хөрөнгө оруулалтын байгууллага нь шууд эсвэл хяналтанд буй байгууллагаараа дамжуулан хөрөнгө оруулалттай холбоотой дараах үйл ажиллагаанд мөн оролцож болно:

- (а) Санхүүжигчид менежментийн үйлчилгээ үзүүлэх ба стратегийн зөвлөгөө өгөх; ба
- (б) Санхүүжигчид зээл, хөрөнгийн баталгаа буюу санхүүгийн баталгаа гэх мэт санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

МЗУ100. Хөрөнгө оруулалтын байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага биш хяналтанд буй байгууллагатай бөгөөд түүний гол зорилго ба үйл ажиллагаа нь МЗУ98-МЗУ99-р параграфт тодорхойлсон үйл ажиллагаа гэх мэт тухайн хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хамааралтай, хөрөнгө оруулалтын үйлчилгээ буюу үйл ажиллагааг тэрхүү байгууллагад болон бусад талуудад үзүүлэх явдал бол хөрөнгө оруулалтын байгууллага нь 57-р параграфт заасны дагуу уг хяналтанд буй байгууллагыг нэгтгэнэ. Хэрэв хөрөнгө оруулалттай холбоотой үйлчилгээ буюу үйл ажиллагааг эрхлэн үзүүлдэг хяналтанд буй байгууллага нь өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага бол хяналт тавигч байгууллага болох хөрөнгө оруулалтын байгууллага нь 56-р параграфт заасны дагуу уг хяналтанд буй байгууллагыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ.

### *Гарах стратеги*

МЗУ101. Байгууллагын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь түүний бизнесийн зорилгын талаархи нотолгоогоор бас хангадаг. Хөрөнгө оруулалтын байгууллагыг бусад байгууллагаас ялгах нэг шинж нь хөрөнгө оруулалтын байгууллага өөрийн хөрөнгө оруулалтыг хугацаагүй эзэмшихээр төлөвлөдөггүй явдал юм; өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын байгууллага нь хөрөнгө оруулалтыг тодорхой хязгаарлагдмал хугацаанд эзэмшдэг. Өмчийн хөрөнгө оруулалт ба санхүүгийн бус хөрөнгийн хөрөнгө оруулалтыг хугацаагүй эзэмших боломжтой учраас хөрөнгө оруулалтын байгууллага нь өөрийн бараг бүх өмчийн хөрөнгө оруулалт болон санхүүгийн бус хөрөнгийн хөрөнгө оруулалтаас капиталын үнийн өсөлтийг хэрхэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгааг баримтжуулсан гарах стратегитай байдаг. Хөрөнгө оруулалтын байгууллага нь хугацаагүй эзэмших боломжтой аливаа өрийн хэрэглүүр, тухайлбал хугацаагүй өрийн хөрөнгө оруулалтын хувьд мөн гарах стратегитай байх ёстой. Байгууллага нь бие даасан хөрөнгө оруулалт тус

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

бүрийн хувьд гарах тусгай стратегийг баримтжуулах шаардлагагүй боловч хөрөнгө оруулалтын өөр өөр төрлүүд буюу багцуудын хувьд боломжит өөр өөр стратегийг, үүн дотроо тухайн хөрөнгө оруулалтаас гарах хугацааны бодит мужийг тодорхойлох шаардлагатай. Гэрээг зөрчих, үр дүнгүй байх гэх мэт үл биелүүлэх үйл явдал тохиолдсон үед зөвхөн хэрэгжүүлэх, гарах стратегийг энэхүү үнэлгээний зорилгын хувьд гарах стратеги гэж үзэхгүй.

МЗУ102. Гарах стратеги нь хөрөнгө оруулалтын төрлөөс хамааран өөр өөр байж болно. Хувийн өмчийн үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтын хувьд гарах стратегийн жишээнд дараах зүйлс хамаарна. Үүнд: хувьцааг анхдагч зах зээлд гаргах, үнэт цаасыг хувиараа худалдах, бизнесийг худалдах, санхүүжигч дэх өмчлөлийн хувь оролцоог (хөрөнгө оруулагчдад) хуваарилах, хөрөнгийг борлуулах (үүн дотроо, уг санхүүжигчийг татан буулгахын хамтаар түүний хөрөнгийг борлуулах). Олон нийтийн нээлттэй зах зээлд арилжаалагддаг өмчийн хөрөнгө оруулалтын хувьд гарах стратегийн жишээнд дараах зүйлс хамаарна. Үүнд: хувиараа болон олон нийтийн зах зээл дээр уг хөрөнгө оруулалтыг борлуулах. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын хувьд гарах стратегийн жишээнд дараах зүйлс хамаарна. Үүнд: үл хөдлөх хөрөнгийн мэргэшсэн дилерээр дамжуулан эсвэл нээлттэй зах зээлд уг үл хөдлөх хөрөнгийг борлуулах.

МЗУ103. Хөрөнгө оруулалтын байгууллага нь хууль эрх зүй, зохицуулалт, татвар буюу түүнтэй ижил төсөөтэй бизнесийн шалтгаанаар тухайн байгууллагатай холбоотойгоор үүсгэн байгуулагдсан өөр хөрөнгө оруулалтын байгууллагад хөрөнгө оруулалт хийсэн байж болно. Ийм тохиолдолд уг хөрөнгө оруулалтын байгууллагын санхүүжигч нь түүний хөрөнгө оруулалтын хувьд гарах зохих стратегитай бол тухайн хөрөнгө оруулалтын байгууллага нь тэрхүү хөрөнгө оруулалтын хувьд гарах стратегитай байх шаардлагагүй юм.

### **Бодит үнэ цэнийн хэмжилт**

МЗУ104. Бодит үнэ цэнийг ашиглах нь тухайлбал, түүний хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэх эсвэл хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь оролцооны хувьд өмчийн арга ашигласнаас илүү хамааралтай мэдээлэл бий болгоход хүргэдэг тул хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтын чухал нэг элемент нь түүний бараг бүх хөрөнгө оруулалтын үр дүнг бодит үнэ цэнэд үндэслэн хэмжиж, үнэлэх явдал юм. Тодорхойлолтын уг элементийн шаардлагыг хангаж байгаа гэдгээ харуулахын тулд хөрөнгө оруулалтын байгууллага нь:

- (а) УСНББОУС-уудаар бодит үнэ цэнийг шаарддаг буюу зөвшөөрдөг аливаа тохиолдолд бодит үнэ цэнийн талаархи мэдээллээр хөрөнгө оруулагчдыг хангах бөгөөд өөрийн бараг бүх хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайландаа бодит үнэ цэнээр хэмжинэ; ба
- (б) Өөрийн бараг бүх хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлэх ба хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа анхдагч хэмжилт болгон бодит үнэ

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

цэнийг ашигладаг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд (УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-д тодорхойлсон) бодит үнэ цэнийн талаархи мэдээллийг дотооддоо тайлагнана.

МЗУ105. МЗУ104(а) параграфын шаардлагыг хангахын тулд хөрөнгө оруулалтын байгууллага нь:

- (а) Хөрөнгө оруулалтын зориулалттай аливаа үл хөдлөх хөрөнгийг УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-д заасан бодит үнэ цэнийн загвар ашигласнаар тайлагнах сонголт хийнэ;
- (б) Хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын хувьд УСНББОУС 36-д заасан, өмчийн аргыг мөрдөхөөс чөлөөлөгдөх нөхцлийг сонгоно; ба
- (в) УСНББОУС 29-ийн шаардлагуудын дагуу өөрийн санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

МЗУ106. Хөрөнгө оруулалтын байгууллага нь төв оффисын үл хөдлөх хөрөнгө ба холбогдох тоног төхөөрөмж гэх мэт хөрөнгө оруулалтын бус зарим хөрөнгө, мөн санхүүгийн өр төлбөртэй байж болно. Хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтын бодит үнэ цэнийн хэмжилтийн элементийг тухайн хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтанд мөрдөнө. Иймээс хөрөнгө оруулалтын байгууллага нь хөрөнгө оруулалтын бус хөрөнгө болон өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжих шаардлагагүй юм.

## Хавсралт Б

### Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт

[Хассан]



## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 35-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Зорилго

ДҮ1. УСНББОУС 35-ын дүгнэлтүүдэд хүрэхдээ УСНББОУС3-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. Энэ Стандарт нь НББОУС3-өөс гаргасан, СТОУС 10, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* (2011 онд гаргасан ба үүн дотроо, 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүд)-д үндэслэсэн тул УСНББОУС 35 нь СТОУС 10-ын гол шаардлагуудаас гажсан эсвэл УСНББОУС3 нь ийм гажилтыг авч үзсэн зөвхөн тэдгээр талбаруудыг Дүгнэлтийн Үндэслэлд хамруулсан.

### Тойм

ДҮ2. УСНББОУС3 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны тайлагналыг зохицуулах УСНББОУС-уудыг шинэчлэх төслийн ажлыг 2012 онд эхэлсэн. *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцоо* гэж хамтад нь нэрлэх, Саналын Төсөл (СТ) 48-52-ыг УСНББОУС3 нь 2013 оны 10 дугаар сард гаргасан. СТ 49, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* нь СТОУС 10, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-д үндэслэсэн бөгөөд УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан* дахь улсын секторын холбогдох засвар өөрчлөлтүүдийг авч үзсэн. 2015 оны 01 дүгээр сард УСНББОУС3 нь шинэ таван УСНББОУС-ыг, үүн дотроо УСНББОУС 35-ыг гаргасан. Эдгээр шинэ УСНББОУС-ууд нь УСНББОУС 6, УСНББОУС 7, *Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт*, УСНББОУС 8, *Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо*-г орлох юм.

### Үйл явц

ДҮ3. Энэ Стандартыг боловсруулахдаа, УСНББОУС3 нь улсын секторын асуудлууд болон бусад сектороос илүүтэйгээр улсын секторт түгээмэл байх нөхцөл байдлуудыг авч үзэхийн тулд тусгайлан боловсруулсан, УСНББОУС 6-гийн тэдгээр төлөв байдлуудыг харгалзан үзсэн. УСНББОУС3 нь эдгээр асуудлуудыг энэ Стандартад авч үзэхэд голлон анхаарал хандуулсан. Шаардлагагүй зөрүүтэй байдлаас зайлсхийхийн тулд *Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн Гарын Авлага 2014* (ЗГССГА 2014)-ын зорилгын хувьд тухайн байгууллага нь хяналтанд буй эсэхийг үнэлэх талаархи заавар удирдамжийг УСНББОУС3 нь мөн харгалзан тусгасан. Улсын секторын орчныг үлгэрчлэн харуулсан нэмэлт жишээнүүдийг боловсруулахдаа, УСНББОУС3 нь үндэсний стандарт тогтоогчдын болон засгийн газрын секторуудад хяналт тавих үүрэг хүлээсэн этгээдүүдийн боловсруулсан заавар удирдамжийг мөн авч үзсэн.

*Засгийн Газрын Санхүүгийн Статистиктай уялдуулалт*

ДҮ4. СТ 49-ийг боловсруулах үед болон энэ Стандартыг эцэслэн дуусгах процессын нэг хэсэг болгон УСНББОУСЗ нь хяналтын тодорхойлолтын хоорондох ижил төсөөтэй ба зөрүүтэй талуудын шинжилгээг ЗГССГА 2014 (ЗГСС 2014-тэй уялдуулсан Үндэсний Тооцооны Систем 2008 (ҮТС 2008)), түүнчлэн уг санал болгосон Стандарт дахь холбогдох үзүүлэлтүүд болон заавар удирдамжийн хамтаар авч үзсэн. ЗГССГА ба санхүүгийн тайлагналын хоорондох зарим зөрүүтэй байдал нь тэдгээрийн шинж төрөл болон өөр өөр зорилтуудаас шалтгаалдаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Жишээлбэл; засгийн газрын нэгжүүдийн эдийн засгийн шинж төрөлд үндэслэн институцийн нэгжүүдийг секторуудад ангилах ангилал нь макро эдийн засгийн статистикийн тайлагнал ба нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын хоорондох гол ялгаатай тал хэвээр байх юм. Түүнчлэн, макро эдийн засгийн статистик дахь зах зээлийн үйлдвэрлэгчид ба зах зээлийн бус үйлдвэрлэгчдийг өөр хооронд нь ялган тодорхойлох нь засгийн газрын үндсэн сектор эсвэл улсын корпорацийн сектор гэсэн ангиллын нэр томъёонд зөрүү үүсэхэд, ингэснээр хэдийгээр хяналтын тухай ойлголтын хувьд нэг ижил зарчим ба үзэл баримтлалын заавар удирдамжтай боловч улсын секторын нийт ангилал ялгаатай болоход хүргэдэг.

ДҮ5. Энэ Стандартыг боловсруулах явцад УСНББОУСЗ нь ЗГССГА 2014-ийн заавар удирдамжтай илүү нягт уялдуулах буюу зөрүүгийн шинж төрлийг илүү ойлгомжтой тайлбарлахын тулд нилээд хүчин чармайлт гаргасан. УСНББОУСЗ нь дараах зүйлсийн хувьд ЗГССГА-ын шаардлагуудыг тусгайлан харгалзан үзсэн:

- (а) Засгийн газрын секторуудаар тайлагнахаас ялгаатай нь, бүх хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэх шаардлагатай эсэх;
- (б) Энэ Стандарт дахь хяналтын тухай ойлголт ухагдахуун ба ЗГССГА 2014-д баримталсан хандлагын хоорондох төсөөтэй байдал, үүн дотроо ҮТС 2008 дахь ашгийн бус байгууллагууд ба корпорациудын хяналтын үзүүлэлтүүдийг харгалзах;
- (в) Зохицуулалтын хяналт ба санхүүгийн тайлагналын зорилго бүхий хяналтын хоорондох ялгаатай талууд; ба;
- (г) Алтан хувьцаатай холбоотой эрхүүд.

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэлийн дараагийн хэсгүүдэд эдгээр асуудлын заримыг илүү дэлгэрэнгүй авч үзсэн.

**Цар хүрээ (3-11-р параграф)**

*Бүрэн-өмчлөлт ба хэсэгчилсэн-өмчлөлт хяналт тавигч байгууллагууд*

ДҮ6. Тодорхой нөхцлийг хангасан бүрэн-өмчлөлт буюу хэсэгчилсэн өмчлөлт хяналт тавигч байгууллагууд, түүнчлэн ажил эрхлэлтийн дараах болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хөтөлбөрүүд нь УСНББОУС 6 болон СТОУС 10-ын шаардлагуудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлан

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

толилуулах албагүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Өөрөө хяналтанд буй байгууллага болох хяналт тавигч байгууллага нь “нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэрэглэгчид оршин байх эсвэл тэдний мэдээллийн хэрэгцээг уг хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар хангах магадлалгүй” зөвхөн тийм тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулах шаардлагагүй гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн. Ийм хяналт тавигч байгууллагууд нь засгийн газрын гол сектор буюу үйл ажиллагааг төлөөлдөг бөгөөд өөрийн хариуцлагын буюу шийдвэр гаргалтын зорилгын хувьд нэгтгэсэн санхүүгийн тайланг шаардах тийм хэрэглэгчид байгаа тохиолдолд энэхүү хязгаарлалт нь хэрэглэгчдийг хамгаалах санаа зорилготой байдаг.

*Хяналтанд буй бүх байгууллагуудын хувьд нэгтгэлийн шаардлагуудыг мөрдөх*

ДҮ7. СТОУС 10 ба УСНББОУС 6-гийн ерөнхий зарчим бол хяналт тавигч байгууллага нь өөрийн хяналтанд буй бүх байгууллагуудыг мөр мөрөөр нэгтгэх явдал гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Бусад байгууллагууд дахь улсын секторын байгууллагын оролцооны (ялангуяа засгийн газар ба бусад байгууллагуудын хоорондох харилцааны) боломжит хамрах хэмжээ ба нарийн цогц байдал нь сүүлийн жилүүдэд нэмэгдсэн гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Засгийн газрын хөндлөнгийн оролцоо нь бусад байгууллагуудад өргөн хүрээний хувь оролцоо бүхий засгийн газруудын (болон улсын секторын бусад байгууллагуудын) хувьд гол хүчин зүйл болсон бөгөөд үүний зарим нь энэ Стандартад тодорхойлсон хяналт үүсэхэд хүргэж болох юм. Засгийн газар нь хяналтанд буй маш олон тооны байгууллагуудтай, өмнө нь зөвхөн хувийн хэвшлийн үйл ажиллагаа гэж үздэг байсан тийм үйл ажиллагааг эрхэлдэг хяналтанд буй байгууллагуудтай, түр зуурын хяналт бүхий хяналтанд буй байгууллагуудтай байх тохиолдолд нэгтгэлийн ач холбогдол нь өртөг, өгөөжийг харгалзсанаар тэдгээр хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэх нь зохистой эсэх талаар зарим эргэлзээ төрүүлдэг.

ДҮ8. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзвэл хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэх хэрэгтэй эсэх асуудалд УСНББОУСЗ нь ихээхэн анхаарал хандуулсан. Хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг (i) хяналт тавигч байгууллага ба хяналтанд буй байгууллагуудын аль алины тусдаа санхүүгийн тайлан; (ii) гүйцэтгэлийн тайлан илтгэл; ба (iii) статистикийн тайлан гэх мэт бусад тайлан, илтгэлээр мөн хангаж болно гэдгийг тэмдэглэхийн хамтаар УСНББОУСЗ нь нэгтгэсэн санхүүгийн тайлангаар бүрдүүлэх мэдээлэлд голлон анхаарсан. Хэдийгээр УСНББОУСЗ-ийн зарим хэлэлцүүлэг нь хяналт тавигч байгууллага болох улсын секторын аливаа төрлийн байгууллагад хамааралтай боловч харгалзан үзсэн олон асуудлууд нь нийт засгийн газрын түвшинд илүү хамааралтай байсан. Хяналтанд буй дараах төрлийн байгууллагуудтай холбоотойгоор УСНББОУСЗ нь нэгтгэлийн ач холбогдолтой байдлын талаархи санал бодлыг харгалзан үзсэн (гэвч эдгээр өргөн хүрээтэй ангиллыг нийтлэг хэрэглэх боломжгүй гэдгийг тэмдэглэсэн).

(a) Газар хэлтсүүд ба яамд;

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- (б) Засгийн газрын агентлагууд;
- (в) [Улсын Үйлдвэрийн Газруудад (УҮГ)] (2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргаснаас хойш ийм дөрвөлжин хаалтанд тусгасан нэр томъёог цаашид ашиглахаа больсон);
- (г) Санхүүгийн байгууллагууд (засгийн газраас санхүүжүүлсэн байгууллагууд хамаарахгүй); ба
- (д) Бусад хөрөнгө оруулалтууд (үүн дотроо, зохион байгуулалттай хөрөнгө оруулалт, дагалдах хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын байгууллагууд). Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн уналтаас сэргийлэх гэх мэт өөр зорилгыг ханган биелүүлэх явцад олж эзэмшсэн хувь оролцоог илэрхийлэхийн тулд “дагалдах хөрөнгө оруулалт” нэр томъёог ашигладаг.

ДҮ9. Хяналтанд буй газар хэлтсүүд, яамд, засгийн газрын агентлагуудыг нэгтгэх нь зүйтэй гэсэн ерөнхий тохиролцоонд хүрсэн боловч нэгтгэсэн санхүүгийн мэдээлэл бэлтгэх өртөг зардал нь хяналтанд буй байгууллагуудын бусад ангиллын хувьд зохистой эсэхэд зарим гишүүд итгэлгүй байгааг УСНББОУСЗ нь тэмдэглэсэн.

ДҮ10. УСНББОУСЗ нь засгийн газрын хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэх шаардлагыг дэмжих шалтгаан үндэслэлийг дурдсан. Үүнд:

- (а) Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь засгийн газрын үйл ажиллагаа ба одоогийн санхүүгийн байдлын дүр зургийг харуулдаг. Энэхүү дүр зураг нь тодорхой сектортой холбоотой эрсдлийг хэрэглэгч нар орхигдуулахгүй байх боломж олгодог. Энэ нь бүхэлдээ засгийн газрын үр дүнг харуулдаг.
- (б) Нэгтгэх хэрэггүй байгууллагуудын ангиллыг тодорхойлоход төвөгтэй байж болно. Ийм оролдлого нь дүрэмд суурилсан стандарт бий болгоход хүргэж болох юм. Жишээлбэл; санхүүгийн хямралаас аврагдсан байгууллагуудыг улс орнуудын хооронд болон цаг хугацааны явцад нэг тууштай сууриар тус тусад нь тодорхойлоход хүндрэлтэй байж болох юм. УҮГ-уудад хамаарах аливаа тусдаа саналуудын хувьд үүнтэй адил асуудал үүсэж болно. Хэдийгээр энэ Стандартыг гаргах үед УҮГ нэр томъёог УСНББОУС-ын хүрээнд тодорхойлсон байсан боловч янз бүрийн улс орнуудын практикт энэ тодорхойлолтыг хэрэглэх арга замууд нь өөр өөр байгааг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Нягтлан бодох бүртгэлийн ялгаатай шаардлагууд тохиромжтой байж болох аливаа байгууллагуудын бүлгийг ойлгомжтой тодорхойлох асуудлаас гадна, өөр өөр төрлийн байгууллагууд нь ийм ижил төсөөтэй үйл ажиллагааг тухайн улсын хүрээнд болон улс хооронд эрхлэн явуулдаг байж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс нягтлан бодох бүртгэлийн өөр өөр арга хандлагуудыг санал болгох нь тухайн нэг улсын хүрээнд дэх байгууллагуудын бүлгийн хувьд тууштай арга хандлагад хүргэж

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

болох боловч ижил төсөөтэй үйл ажиллагааны зэрэгцүүлэгдэх тайлагналыг бий болгохгүй байж болох юм.

- (в) Хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэх нь ижил төсөөтэй зүйлсийг нэг адил арга замаар тайлагнах жишээ юм. Нэгтгэлд хамруулахгүй байх нь санхүүгийн тайлангийн уялдаа холбоог бууруулдаг. Тусдаа арга хандлага буюу тодруулга зохистой гэж үзэж болох олон байгууллагууд байж болно гэдгийг харгалзан үзвэл ингэж нэгтгэлд хамруулахгүй байх нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн уялдаа холбоонд сөргөөр нөлөөлж болох юм.
- (г) Нийт засгийн газрын түвшний санхүүгийн тайлан нь тусдаа санхүүгийн тайлангуудаас өөр төлөв хандлагатай байдаг. Тусдаа санхүүгийн тайлан нь үндсэн засгийн газрын үйл ажиллагааны талаархи мэдээллээр хангадаг.

ДҮ11. УСНББОУСЗ нь засгийн газрын хяналтанд буй зарим байгууллагуудыг нэгтгэхийн эсрэг гаргасан шалтгаан үндэслэлийг бас дурдсан. Үүнд:

- (а) Үндсэн засгийн газрын үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг нэгтгэх нь тухайн засгийн газрын үр дүн болон санхүүгийн байдлын толилуулгыг бүрхэгдүүлж болох юм. Хяналтанд буй янз бүрийн байгууллагууд, үүн дотроо үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, томоохон санхүүгийн байгууллагууд, түр зуур хяналтанд буй байгууллагууд, нийгмийн зорилтуудтай нийцэхгүй санхүүгийн зорилтууд бүхий байгууллагуудтай холбоотойгоор энэхүү шалтгаан үндэслэлийг гаргасан.
- (б) Хяналтанд буй байгууллагуудын зарим ангиллын хувьд өмчийн тайлагнал нь өндөр өртөг зардал гаргахгүй буюу үндсэн засгийн газрын мэдээллийг бүрхэгдүүлэхгүйгээр тухайн худалдан авалтын дараах, санхүүгийн үр дүнгийн талаархи зохих мэдээллээр хангадаг гэж зарим хүмүүс үздэг.
- (в) Санхүүгийн хямралаас аврагдсан байгууллагууд нь үндсэн засгийн газрын үйл ажиллагааг төлөөлөн илэрхийлэхгүй бөгөөд урт хугацааны хөрөнгө оруулалт хийх санаа зорилгогүй тул ийм байгууллагуудыг нэгтгэх нь тохиромжгүй гэж зарим хүмүүс үзсэн.
- (г) Засгийн газар нь хяналтанд буй маш олон тооны байгууллагуудтай тохиолдолд нэгтгэх үйл явцын өртөг зардал нь өндөр байх бөгөөд тэдгээр байгууллагуудыг мөр мөрөөр нэгтгэсний өгөөжөөс давж илүү гарна гэж ойлгож болох юм.

ДҮ12. Хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэхийг дэмжих ба эсэргүүцэх эдгээр учир шалтгаануудыг тусгахдаа УСНББОУСЗ нь дараах зүйлсийг харгалзан үзсэн:

- (а) *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал (Онолын Үзэл Баримтлал)*-д заасан санхүүгийн тайлагналын зорилго;

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- (б) Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага ба нэгтгэсэн санхүүгийн мэдээллийн ач холбогдлын (ялангуяа хяналтанд буй тодорхой төрлийн байгууллагуудын хувьд нэгтгэсэн санхүүгийн мэдээллийн ач холбогдлын) талаархи нотолгооны хязгаарлагдмал байдал;
- (в) Нийт засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх хүрээ;
- (г) Уг санал болгосон Стандарт дахь хяналтын тодорхойлолт ба нэгтгэлийн шаардлагуудын уялдаа холбоо; ба
- (д) Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт тогтоогчийн хувьд УСНББОУСЗ-ийн гүйцэтгэх үүрэг.

ДҮ13. Санхүүгийн тайлагналын зорилго нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой мэдээллээр хангах явдал гэж *Онолын Үзэл Баримтлал*-ын Бүлэг 2-д тодорхойлсон болохыг УСНББОУСЗ нь санхүүгийн тайлагналын зорилготой холбоотойгоор тэмдэглэсэн. Улсын секторт төсөв чухал ач холбогдолтой (ба төсөвтэй нийцэж буйг харуулах нь ач холбогдолтой) тул нэгтгэсэн санхүүгийн тайлан нь засгийн газрын төсвийн байгууллагыг бүрдүүлдэг зөвхөн тэдгээр байгууллагуудыг нэгтгэх хэрэгтэй гэсэн шалтгаан үндэслэлийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Гэвч уг төсвийн байгууллагын хандлага нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын хувьд дараах шалтгааны улмаас тохиромжгүй гэж УСНББОУСЗ үзсэн:

- (а) Засгийн газрын төсөвт ямар байгууллагуудыг тусган оруулах талаархи шийдвэр нь тухайн байгууллагын бие даасан байдлын зэрэг хэмжээ, зах зээлийн бараа бүтээгдэхүүн нийлүүлэх буюу арилжааны өгөөж хүртэх хэмжээнээс өөр бусад хүчин зүйлсэд үндэслэдэг байж болох юм.
- (б) Засгийн газрын төсөвт ямар байгууллагуудыг тусган оруулах талаархи шийдвэр нь тухайн байгууллага үйл ажиллагаагаа өөрөө санхүүжүүлэх санаа зорилготой эсэхтэй ихэвчлэн холбоотой байдаг. Өөрийгөө санхүүжүүлдэг байгууллагуудыг засгийн газрын төсөвт оруулахгүй байх нь үндсэндээ тэдгээр үйл ажиллагааны орлого, зардлыг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах боломж олгодог бөгөөд засгийн газрын хяналтанд буй бүх ажил гүйлгээний мөн чанарыг ийм төсвийн секторын мэдээлэлд тусгадаггүй гэсэн утгыг илэрхийлэх юм.
- (в) Улс орны төсвийн хил хязгаарыг тухайн улсын хүрээнд тодорхойлдог. Хэрэв санхүүгийн тайлагнал нь төсвийн секторт үндэслэдэг бол засгийн газруудын гаргадаг, олон улсын хэмжээнд стандартчилсан ба зэрэгцүүлэгдэх санхүүгийн тайлагналгүй байх байсан.

ДҮ14. УСНББОУС 6 нь доор дурдсан нотолгоо бүхий хяналтанд буй байгууллагуудаас бусад, бүх хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэхийг шаарддаг: (а) тухайн хяналтанд буй байгууллагыг худалдан авалтын өдрөөс хойш арван хоёр сарын дотор зөвхөн худалдан борлуулах зорилгоор эзэмшиж байгаа учраас түр зуур хянах санаа зорилготой, ба (б) удирдлага нь худалдан авагчийг идэвхитэй эрж хайж байгаа. Ийм түр зуур хяналтанд буй байгууллагуудыг санхүүгийн хэрэглүүр байдлаар

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

тайлагнахыг шаарддаг. Түр зуур хяналтанд буй байгууллагуудын ийм арга хандлагыг энэхүү санал болгосон Стандартад бас тусган шаардах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. УСНББОУС 6-гийн шаардлагуудтай холбоотойгоор анхаарах олон асуудал байгааг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Үүнд дараах асуудлууд хамаарна:

- (а) Түр зуур хяналтанд буй байгууллагуудыг тодорхойлох хүндрэлтэй байдал;
- (б) Хоёроос олон жилээр эзэмших хяналтанд буй байгууллагуудын хувьд нягтлан бодох бүртгэлийн өөр арга хандлага тохиромжтой гэдгийг зөвтгөн батлахад төвөгтэй байдал (анх түр зуур хяналтанд байлгана гэж үзэж байсан зарим байгууллагуудын хувьд ийм тохиолдол үүсэж болно);
- (в) Хөрөнгө оруулалтыг түүний одоогийн хэлбэрээр худалдан борлуулахад төвөгтэй байдал. Түр зуур хяналтанд буй байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг худалдан борлуулахын тулд улсын секторын байгууллага нь зарим эрсдлийн хувьд хариуцлага хүлээх шаардлагатай байж болох юм. Ийм байгууллагуудыг санхүүгийн хэрэглүүр гэж тайлагнах нь тухайн хөрөнгө оруулалттай холбоотой эрсдлийн зөвхөн хэсэгчилсэн төлөөллөөр хангадаг;
- (г) Хэрэв улсын секторын байгууллага нь “түр зуур” хяналтанд буй байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтаасаа эрсдэл хүлээдэг бол уг эрсдлийг хяналтанд буй бусад байгууллагуудаас үүсэх эрсдэлтэй нийцсэн байдлаар тайлагнах хэрэгтэй; ба
- (д) Тайлагнагч байгууллагын зүгээс нэмэлт тайлбар хийх нь түр зуур хяналтанд буй томоохон байгууллагуудыг нэгтгэсэн үед үүсэх зарим асуудлуудыг авч үзэж болох юм.

ДҮ15. Иймээс УСНББОУСЗ нь түр зуур хяналтанд буй байгууллагуудын хувьд нягтлан бодох бүртгэлийн өөр арга хандлага шаардахгүй байхаар шийдвэрлэсэн. СТ 49-д хариулт өгсөн хүмүүс нь УСНББОУСЗ-тэй ижил шалтгаан үндэслэлээр энэхүү саналыг ерөнхийдөө хүлээн зөвшөөрсөн. Хариулт өгсөн хүмүүсийн саналыг авч хэлэлцэхдээ, УСНББОУСЗ нь түр зуур хяналтанд буй байгууллагуудыг, ялангуяа иргэдийн эрх ашгийг хамгаалахын тулд засгийн газрын худалдан авсан байгууллагуудыг нэгтгэлээс чөлөөлөх хэрэгтэй гэж тэдний үзсэн шалтгаан үндэслэлийг хүлээн зөвшөөрсөн. Гэвч УСНББОУСЗ нь ийм нөхцөл байдлыг тайлагнах янз бүрийн улс орнуудын туршлага, түүнчлэн зарим улс оронд ийм байгууллагуудыг нэгтгэдэг байсан гэдгийг бас онцлон тэмдэглэсэн. Мөн УСНББОУСЗ нь уг чөлөөлөлтийг болихын төлөөх дэмжлэгийн хувийн жинг харгалзан үзсэн. Хариулт өгсөн хүмүүс нь ийм хөрөнгө оруулалтыг анхны төсөөлж байснаас ихэвчлэн илүү урт хугацаанд эзэмшиж болно гэж мэдэгдсэн. Худалдан борлуулах зорилгоор олж эзэмшсэн байгууллагуудын хувьд УСНББОУСЗ нь нэмэлт тодруулга шаардахаар харгалзан үзэж буйг уг хариулт өгсөн зарим хүмүүс дэмжсэн. УСНББОУСЗ нь борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад байгууллагууд дахь хувь оролцооны

тодруулга хийх шаардлагыг УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-д оруулахыг зөвшөөрсөн.

- ДҮ16. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахад нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ач холбогдлын талаархи судалгаа байгаа эсэхийг харгалзан үзэх үедээ, УСНББОУС3 нь хэдийгээр нягтлан бодох бүртгэлийн аккрузал суурийг мөрдөж буй засгийн газруудын тоо нэмэгдэж байгаа боловч энэ нь харьцангуй сүүлийн үеийн чиг хандлага бөгөөд үндсэн засгийн газрын үйл ажиллагааг эхлээд нэгтгэж, цаг хугацаа ба нөөцийн боломжийг харгалзан бусад ангиллын байгууллагуудыг дараа нь нэгтгэх замаар нэгтгэлийг ихэвчлэн үе шаттайгаар хэрэгжүүлдэг гэдгийг цохон тэмдэглэсэн. Үүний улмаас, нийт засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулдаг улс орон одоогоор цөөхөн байгаа бөгөөд нийт засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ач холбогдлын талаархи туршлагад суурилсан судалгаа хязгаарлагдмал байна. Өнөөг хүртэл хийгдсэн судалгаа нь хяналтанд буй зарим төрлийн байгууллагуудыг нэгтгэх эсвэл тэдгээрийг өөр хувилбар арга замаар тайлагнахын ач холбогдолд биш, харин нэгтгэсэн санхүүгийн тайланг хэн ашиглах эсэх ба нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий өгөөжид голлон чиглэгдэх хандлагатай байсан. Өөрийн хэлэлцүүлгийн нэг хэсэг болгон УСНББОУС3 нь түр зуур хяналтанд буй байгууллагууд гэх мэт хяналтанд буй байгууллагуудын дэд хэсгүүдийн талаархи мэдээллийг тайлагнаж, толилуулах өөр хувилбар арга замуудыг харгалзан үзсэн. Өөр байдлаар тайлагнаж болох эсвэл нэмэлт тодруулга шаардлагатай байж болох хяналтанд буй байгууллагуудын ангиллыг тууштай тодорхойлоход хүндрэлтэй гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн.
- ДҮ17. НББОУС3 нь хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжүүдийн талаархи өөрийн шаардлагуудыг боловсруулах үедээ хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад голлон анхаарал хандуулсан гэдгийг УСНББОУС3 онцлон тэмдэглэсэн. Хөрөнгө оруулалтын байгууллагуудтай холбоотойгоор УСНББОУС3-ийн харгалзан үзсэн асуудлуудыг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд дараа авч үзнэ.
- ДҮ18. Олон засгийн газар нь нэгтгэсэн санхүүгийн мэдээллийг секторын хандлагаар толилуулж, үүнийгээ засгийн газрын үндсэн сектор ба улсын (Санхүүгийн ба Санхүүгийн бус) корпорацийн сектороор задлан харуулах статистикийн тайлан бэлтгэдэг гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Энэхүү мэдээллийг ҮТС 2008-д заасан, статистикийн заавар удирдамжийн дагуу эмхтгэн бэлтгэдэг бөгөөд энэ нь эргээд ЗГССГА 2014 болон Европын Тооцооны Систем 2010 (ЕТС 2010)-ын заавар удирдамжтай нийцсэн байдаг. УСНББОУС-ын арга хандлагад үндэслэн, нийт засгийн газрын данс тооцоог эмхтгэн бүрдүүлэх өөр нэг хувилбар гэж ийм статистик арга хандлагыг үзэж болох эсэхийг УСНББОУС3 харгалзан үзсэн. УСНББОУС 22, *Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга* нь нэгтгэсэн санхүүгийн тайланд ийм статистик мэдээллийг толилуулах заавар удирдамжаар хангадаг гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Гэвч УСНББОУС 22 нь нэгтгэсэн санхүүгийн тайланд ийм мэдээллийг тусган оруулахыг шаардаагүй, мөн хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэх өөр нэг хувилбар арга байдлаар ийм мэдээлэл толилуулахыг зөвшөөрөөгүй. Хэдийгээр статистикийн тайлагнал нь чухал



## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

үүрэг гүйцэтгэдэг бөгөөд улс орнуудын хооронд зэрэгцүүлэгдэх боломжтой мэдээллээр хангадаг гэдгийг УСНББОУСЗ нь тэмдэглэсэн боловч ийм мэдээлэл нь өөр зорилготой бөгөөд засгийн газрын бүх үйл ажиллагааны дүр зургийг харуулах уг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үүргийг гүйцэтгэхгүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Түүнчлэн, үндэсний засгийн газраас бусад засгийн газрууд нь статистикийн секторын мэдээлэл бэлтгүүлэх тийм бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс УСНББОУС 22-т оруулсан аливаа өөрчлөлт нь УСНББОУС 6-УСНББОУС 8-ыг шинэчлэн өөрчлөх түүний төслийн нэг хэсэг болохгүй гэдгийг УСНББОУСЗ онцлон дурдсан. Хэдийгээр УСНББОУСЗ нь статистикийн секторын талаархи мэдээллийг толилуулах заавар удирдамжийг энэ Стандартад оруулахгүй байхаар шийдвэрлэсэн боловч засгийн газрууд нь статистикийн сектороор задлан харуулсан, тийм нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулж болно гэж мэдэгдсэн.

ДҮ19. Иймээс хөрөнгө оруулалтын байгууллагуудтай холбоотойгоор нэгтгэлээс чөлөөлөхөөс бусад (энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд тусад нь авч хэлэлцсэн), бүх хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэхийг СТ 49-д санал болгосон. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзсэнээр нэгтгэхгүй байхыг зөвтгөн дэмжих аливаа саналын хамтаар УСНББОУСЗ нь нэгтгэх шаардлагагүй байгууллагуудын тийм ямар нэг ангилал байгаа эсэх талаархи хүмүүсийн саналыг авахыг эрмэлзсэн. Олон хүмүүс хэрэгжүүлэлтийн хүндрэлтэй байдлыг (жишээлбэл; хяналтанд буй маш олон байгууллагуудыг нэгтгэхтэй холбоотой өртөг зардлыг) онцлон дурдсан боловч хариулт ирүүлсэн хүмүүс нь энэхүү саналыг ерөнхийдөө дэмжсэн. Хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь хууль эрх зүйн буюу захиргааны арга замаар үүсгэн байгуулсан тийм тайлагнагч байгууллагууд оршин байх талаар мөн дурдсан бөгөөд ийм байгууллагууд нь уг санал болгосон Стандартын дагуу тодорхойлсон тайлагнагч байгууллагаас өөр байж болохыг тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь хууль эрх зүйн буюу захиргааны арга замаар үүсгэн байгуулсан тийм тайлагнагч байгууллагууд оршин байх талаар энэ Стандартад тусгахыг зөвшөөрсөн.

### *Хөрөнгө оруулалтын байгууллагууд*

ДҮ20. 2012 оны 10 дугаар сард НББОУСЗ нь *Хөрөнгө Оруулалтын Байгууллагууд* (СТОУС 10, СТОУС 12, НББОУС 27-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)-ыг гаргасан. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн үр дүнд СТОУС 10-аар шаардсанчлан, хөрөнгө оруулалтын байгууллага болох хяналт тавигч байгууллага нь өөрийн ихэнх хөрөнгө оруулалтыг нэгтгэхийн оронд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тайлагнадаг. УСНББОУСЗ нь улсын секторын адилтгах байгууллагуудын хувьд СТОУС 10-ын шаардлагуудын тохиромжтой байдлыг харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь ямар байгууллагуудад ийм шаардлагууд нөлөөлж болохыг эхлээд авч үзсэн. Хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг хангаж болох байгууллагуудад үндэсний баялагийн зарим сан, тэтгэврийн зарим сан, түүнчлэн төр-хувийн хэвшлийн түншлэлийн (ТХХТ) төслүүд болон хувийн хэвшлийн санхүүгийн санаачлагууд (ХХСС) дахь хяналтын хувь оролцоог

эзэмшиж буй зарим сан хамаардаг. Зөвхөн хөрөнгө оруулалтын байгууллагуудад тавигдах аливаа шаардлагууд нь улсын секторын харьцангуй цөөн тооны байгууллагад мөрдөгдөж болно гэдгийг УСНББОУСЗ (хөрөнгө оруулалтын байгууллага байж болох уг байгууллагуудын төрөл, түүнчлэн эдгээр байгууллагуудыг цогц нягтлан бодох бүртгэлийн стандартуудын, үүн дотроо дотоодын стандартуудын дагуу тайлагнах шаардлагатай байж болох бодит байдлыг харгалзсанаар) тэмдэглэсэн.

ДҮ21. НББОУСЗ-д хариулт өгсөн хүмүүс нь НББОУСЗ-ийн уг хөрөнгө оруулалтын байгууллагын саналын төсөлтэй холбоотойгоор санал зөвлөмж гаргасан гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн бөгөөд улсын секторт үүнтэй адилтгах шалтгаан үндэслэлийг мөрдөх эсэхийг харгалзан үзсэн. Боломжит хөрөнгө оруулалтын байгууллагууд (жишээлбэл; үндэсний баялагийн сангууд) гэж НББОУСЗ-өөс тусгайлан тодорхойлсон зарим төрлийн байгууллагууд нь үнэн хэрэгтээ УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагууд байж болохыг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Хөрөнгө оруулалтын байгууллагуудын талаар НББОУСЗ-ийн хийсэн хэлэлцүүлэгт НББОУСЗ нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад голлон анхаарсан гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Өөрсдийн үйл ажиллагаа явуулдаг улс орны тайлагналын үзэл баримтлалаас хамааран улсын секторын хөрөнгө оруулалтын байгууллага нь УСНББОУС, СТОУС эсвэл дотоодын стандартын дагуу тайлагнах шаардлагатай байж болно гэдгийг УСНББОУСЗ дурдсан. Өөрийн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр тайлагнах талаархи хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжид хамаарах СТОУС 10-ын шаардлагууд нь улсын секторт тохиромжтой байж болохыг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. УСНББОУС ба СТОУС-ын хоорондоо уялдан нийцсэн шаардлагууд нь хөрөнгө оруулалтын байгууллага аль стандартыг мөрдөх шаардлагатай эсэхийг тодорхойлох үед нягтлан бодох бүртгэлийг санамсаргүй байдлаар хэрэглэх аливаа боломжит байдлыг бууруулна гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн.

ДҮ22. СТОУС 10 дахь хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолт нь улсын секторт тохиромжтой эсэхийг УСНББОУСЗ харгалзсан үзсэн. Хөрөнгө оруулалтын байгууллага нь өөрийн зорилгыг байнга тогтоох (харин хөрөнгө оруулагчдад өөрийн зорилгыг мэдэгдэх байгууллагаас ялгаатай) гаднын бүрэн эрхтэй байдаг гэдгийг УСНББОУСЗ нь тэмдэглэсэн бөгөөд уг тодорхойлолтод зохих ёсоор нэмэлт өөрчлөлт оруулсан боловч тэрхүү тодорхойлолт нь ихээхэн тохиромжтой болохыг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Өөр бусад зорилтуудын улмаас тухайн байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага биш байх хувилбарын талаархи улсын секторын нэмэлт жишээг харуулах нь ач холбогдолтой эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн.

ДҮ23. Хөрөнгө оруулалтын байгууллагын нийтлэг шинж чанаруудыг улсын секторт ашиглахад тохиромжтой эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Байгууллага нь бүх нийтлэг шинж чанаруудыг хангасан эсэхээс үл хамааран хөрөнгө оруулалтын байгууллага байх боломжийг СТОУС 10-аар зөвшөөрсөн гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Ийм тохиолдолд тухайн

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагын бүх нийтлэг шинж чанаруудтай эсэхээс үл хамааран яагаад хөрөнгө оруулалтын байгууллага болж байгаагаа тайлбарлах шаардлагатай байдаг. СТОУС 10-д тодорхойлсон нийтлэг шинж чанарууд нь улсын секторын хүрээнд нийтлэг шинж чанарууд биш байх магадлалтай эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Жишээлбэл; үндэсний баялгийн сан нь дараах шинж чанартай байж болно:

- (a) Ганц хөрөнгө оруулагчтай (Сайд эсвэл улсын секторын байгууллага) байх. Уг сан нь иргэдийн өмнөөс буюу тэдний эрх ашгийн төлөө хөрөнгө оруулалт хийж байгаа гэж үзэж болно. НББОУСЗ нь хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтын чухал хэсгийг биш, харин энэхүү нийтлэг шинж чанарыг яагаад ашиглахаар шийдвэрлэсэн гэдгийг тайлбарлах үедээ СТОУС 10-ын ДҮ259-р параграфт засгийн газрын өмчлөлт хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн хөтөлбөрийн бүрэн өмчлөлт сан, халамжийн санг тодорхой дурдсан байдаг.
- (б) Холбоотой талууд болох хөрөнгө оруулагчидтай байх. Холбоотой талууд болох тийм хөрөнгө оруулагч бүхий сан нь харилцан холбоогүй олон, өгөөж хүртэгч хөрөнгө оруулагчдын өмнөөс үйл ажиллагаа явуулж болох юм.
- (в) Өмч буюу адилтгах хувь оролцооноос өөр хэлбэрээр өмчлөлийн хувь оролцоотой байх. Үндэсний баялагийн сан дахь өмчлөлийн хувь оролцооны хэлбэр өөрчлөгдөж болно, түүнчлэн НББОУСЗ нь уг тодорхойлолтын чухал хэсгийг биш, харин энэхүү нийтлэг шинж чанаруудыг яагаад ашиглахаар шийдвэрлэснийг тайлбарлах үед СТОУС 10-ын ДҮ264-р параграф нь тэтгэврийн сан болон үндэсний баялагийн санг тусгайлан илэрхийлнэ гэдгийн аль алиныг УСНББОУСЗ тэмдэглэсэн. СТОУС 10-ын ДҮ264-р параграфт “Жишээлбэл; тэтгэвэрийн сан эсвэл ганц шууд хөрөнгө оруулагч бүхий үндэсний баялагийн сан нь тухайн хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй боловч өмчлөлийн нэгжгүй өгөөж хүртэгчидтэй байж болох юм” гэж заасан.

ДҮ24. Хувийн болон улсын секторын хоорондох ялгаатай байдлын улмаас УСНББОУСЗ нь нийтлэг шинж чанаруудыг уг хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтоос тусад нь тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн. Хөрөнгө оруулалтын байгууллагуудын нийтлэг шинж чанаруудын талаархи СТОУС 10 дахь ихэнх хэлэлцүүлэг нь тухайн байгууллага хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг хангасан гэдгээ харуулж болох арга замуудыг илэрхийлсэн гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь уг заавар удирдамжийг хэвээр үлдээх боловч хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтын талаархи бусад заавар удирдамжийн хамт хэрэглэхээр шийдвэрлэсэн. “Тухайн байгууллагад мөнгө санг олгосон хувь хүмүүс буюу аж ахуйн нэгжүүд нь түүний холбоотой тал биш” гэсэн СТОУС 10-ын шинж чанарууд нь улсын секторын нөхцөл байдлыг тусгахгүй бөгөөд уг шинж чанарын талаархи заавар удирдамжийг харгалзахгүй байхыг УСНББОУСЗ зөвшөөрсөн.

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- ДҮ25. Хэдийгээр УСНББОУСЗ нь нийтлэг шинж чанаруудыг уг хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтоос тусад нь тодорхойлохгүй байхаар шийдвэрлэсэн боловч өөрсдийгөө хөрөнгө оруулалтын байгууллага гэж ангилдаг улсын секторын ихэнх байгууллагууд нь хийсэн шүүн тунгаалт ба таамаглалуудын талаархи мэдээллийг тодруулах хэрэгтэй гэж УСНББОУСЗ үзсэн. Эдгээр шүүн тунгаалт ба таамаглалын талаархи тодруулга нь ил тод ойлгомжтой байдлын хувьд чухал ач холбогдолтой бөгөөд хөрөнгө оруулалтын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудын зохих хэрэглээг дэмждэг гэж УСНББОУСЗ дүгнэсэн.
- ДҮ26. Санхүүгийн тодорхой зорилго бүхий хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад улсын секторын байгууллагууд нь илүү өргөн хүрээний зорилготой бөгөөд тэдгээр зорилго нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж болно гэж УСНББОУСЗ тэмдэглэсэн. Улсын секторын байгууллагын зорилго нь мөн Засгийн газрын бодлогын өөрчлөлтийн үр дүнд өөрчлөгдөж болох бөгөөд тэдгээр өөрчлөлтүүд нь хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг өмнө нь хангаж байсан байгууллагыг ингэж хангахаа болиход хүргэж болох юм. Иймээс зорилго өөрчлөгдөх боломжит байдлыг харгалзан үзсэнээр УСНББОУСЗ нь байгууллага өөрийн статусыг тогтмол дахин үнэлэх хэрэгцээ шаардлагыг онцлон тэмдэглэхийг зөвшөөрсөн.
- ДҮ27. СТОУС 10 дахь хөрөнгө оруулалтын байгууллагын шаардлагуудыг тухайн хөрөнгө оруулалтын байгууллагын өөрийнх нь санхүүгийн тайланд мөрдөнө, харин аливаа хөрөнгө оруулалтын байгууллагын хяналт тавигч байгууллага нь үүнийг мөрдөхгүй гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэгдэсэн. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш, хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулах бөгөөд хяналтанд буй бүх байгууллагуудыг үүнд мөр мөрөөр нэгтгэнэ гэж СТОУС 10-аар шаардсан байдаг. Улсын секторын нөхцөл байдал нь энэ асуудалтай холбоотойгоор НББОУСЗ-өөс харгалзан үзсэн шалтгаан үндэслэлд арай их эсвэл бага хувийн жин өгөхөд хүргэх эсэх, түүнчлэн хөрөнгө оруулалтын байгууллагын хяналт тавигч байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн өөр арга хандлага ашиглахыг дэмжих эсэхийг УСНББОУСЗ харгалзсан үзсэн.
- ДҮ28. Түүний хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагуудын ашигладаг бодит үнэ цэнийн арга хандлагыг хэвээр хадгалахыг уг хөрөнгө оруулалтын бус хяналт тавигч байгууллагаас шаардвал хяналт тавигч байгууллагуудыг шууд эсвэл түүний хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагаар дамжуулан шууд бусаар эзэмшсэнээр нягтлан бодох бүртгэлийн өөр үр дагаварт хүргэж болно гэж НББОУСЗ санаа зовж байсныг УСНББОУСЗ тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь улсын секторын хувьд энэ асуудал ач холбогдол багатай гэж үзсэн. Тухайлбал; хувьцаа буюу бусад өмчийн хэрэглүүрээр илэрхийлэгдэх өмчлөлийн хувь оролцоо нь улсын сектор нийтлэг бус байдаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс улсын секторын эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагууд нь эцсийн хяналт тавигч байгууллагад өмчлөлийн хөрөнгө оруулалт эзэмших магадлал багатай бөгөөд мөн тэд уг эдийн засгийн нэгдмэл

байгууллагын хүрээн дэх бусад байгууллагуудад өмчлөлийн хөрөнгө оруулалтыг эзэмших магадлал багатай юм.

ДҮ29. Хэрэглэгчид нь хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын талаархи ямар төрлийн мэдээлэл хамгийн чухал ач холбогдолтой гэж үзэх эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын санхүүгийн тайланд ашигласан хөрөнгө оруулалтын нягтлан бодох бүртгэлийг түүний хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайланд өргөжүүлэн хэрэглэвэл энэ нь хэрэглэгч нарт хамгийн чухал ач холбогдолтой байна гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага бүхий тийм хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулах шаардлагатай бөгөөд үүнд (i) уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнээр хэмжих, ба (ii) хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг энэ Стандартаар шаардсан, нэгтгэлийн ердийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу нэгтгэхийг УСНББОУСЗ санал болгосон. Хяналт тавигч байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагаа өөрийг нь бодит үнэ цэнийн сууриар удирддаггүй тийм нөхцөл байдлыг энэхүү саналд тусгасан эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Харин тухайн байгууллага нь уг хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнийн сууриар удирддаг. Энэхүү арга хандлага нь бусад байгууллагууд дахь өөрийн хөрөнгө оруулалтын хувьд уг хөрөнгө оруулалтын байгууллагын хийх нягтлан бодох бүртгэлтэй мөн нийцэх юм.

ДҮ30. УСНББОУС 35-ыг боловсруулж байх үед НББОУСЗ нь хөрөнгө оруулалтын байгууллагын шаардлагуудын мөрдөлтийн төлөв байдлыг тодруулахыг санал болгосон. НББОУСЗ нь 2014 оны 12 дугаар сард *Хөрөнгө Оруулалтын Аж Ахуйн Нэгжүүд: Нэгтгэлээс Чөлөөлөгдөх Заалтыг Мөрдөх* (СТОУС 10, СТОУС 12, НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)-ийг гаргасан. Эдгээр тодруулгууд нь НББОУСЗ-ийн хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн шаардлагуудыг түүний заасан хугацаанаас өмнө мөрдсөн байгууллагуудын илрүүлсэн хэрэгжүүлэлтийн асуудлуудыг авч үзэхэд ач тустай гэж УСНББОУСЗ үзсэн бөгөөд энэ Стандартад хамааралтай тэдгээр нэмэлт өөрчлөлтийн төлөв байдлуудыг харгалзан тусгасан.

### **Хяналт (18-37-р параграф)**

ДҮ31. СТОУС 10-т заасан, хяналтын гурван шаардлага нь улсын секторт ерөнхийдөө тохиромжтой гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. УСНББОУС 6 нь бүрэн эрх ба өгөөжийн аль алиныг байхыг шаарддаг боловч бүрэн эрх, өгөөж, бүрэн эрх ба өгөөжийн холбоо гэсэн СТОУС 10-ын шаардлагууд нь УСНББОУСЗ-ийн зүгээс УСНББОУС 6-д өмнө нь харгалзан тусгасан хандлагатай ижил төсөөтэй гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь УСНББОУС 6-д ашигласан нэр томъёотой нэгэн адилаар улсын секторын хувьд “үр өгөөж” гэсэн нэр томъёоны оронд “өгөөж” гэсэн нэр томъёо ерөнхийдөө илүү тохиромжтой гэж үзсэн (үүнийг

“Нэр томъёо” гэсэн доорх дэд гарчигт авч хэлэлцсэн). Гэхдээ “үр өгөөж” гэсэн нэр томъёог хөрөнгө оруулалтын байгууллагуудын хүрээнд ашигласан хэвээр байна.

ДҮ32. УСНББОУСЗ нь байгууллагад тавих хяналттай холбоотойгоор Засгийн Газрын Санхүүгийн Статистикт тусгасан арга хандлагыг харгалзан үзсэн. ҮТС 2008-ын 4.80-р параграфт корпорацийн хяналтын найман үзүүлэлт, ашгийн бус байгууллагуудын хяналтын таван үзүүлэлтийг тусгасан бөгөөд “Хэдийгээр нэг үзүүлэлт нь хяналтыг тогтооход хангалттай байж болох боловч бусад тохиолдолд олон үзүүлэлт нь хамтдаа хяналтыг илэрхийлж болно” гэж тайлбарласан. Ерөнхийдөө, статистикийн үзүүлэлтүүдийн чиглэл нь энэ Стандарт дахь арга хандлагатай нэг шугамд байдаг, иймээс хэтийн шинжилгээний практик үр дүн нь давхцах өндөр магадлалтай байдаг. ЗГСС-ийн зарим үзүүлэлтийг дараах параграфт дурдсан.

### **Бүрэн эрх (23-29-р параграф)**

ДҮ33. УСНББОУСЗ нь дараах зүйлсийг гүйцэтгэхийн тулд СТОУС 10-д засвар өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн:

- (а) Улсын секторт гарч тохиолдож болох холбогдох үйл ажиллагааны мужийг тодруулах, санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын хяналт нь холбогдох үйл ажиллагааны хувьд бүрэн эрхтэй байгааг баилан харуулж чадна гэдгийг онцлон тэмдэглэх;
- (б) Зохицуулалтын хяналт ба эдийн засгийн хараат байдал нь энэ Стандартын зорилгын хувьд бүрэн эрхийг бий болгохгүй гэдгийг тодорхой болгох; ба
- (в) Улсын секторт хяналт бий болгоход хүргэх тусгай бүрэн эрхийг, үүн дотроо алтан хувьцаа, бусад байгууллагын Удирдах Зөвлөлийн олонхийг томилох эрх, хууль тогтоомж буюу зохих баримт бичгийн дагуу олж авсан бүрэн эрхийг авч хэлэлцэх.

### *Зохицуулалтын хяналт*

ДҮ34. УСНББОУС 6-д заасан, зохицуулалтын хяналтын талаархи өмнөх заавар удирдамжийг энэ Стандартад тусган оруулах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Ашгийн төлөө байгууллагуудад мөрдөх зорилгоор СТОУС 10-ыг боловсруулсан бөгөөд тэдгээрийн зарим цөөн байгууллага нь хууль тогтоомж болон зохицуулалтыг бий болгох буюу хэрэгжүүлэх бүрэн эрхтэй байдаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Нөгөө талаас, зохицуулалтын бүрэн эрх нь ямагт улсын секторт үүсдэг болохыг засгийн газрын мөн чанар илэрхийлдэг.

ДҮ35. Зохицуулалтын хяналтын талаархи заавар удирдамжийг энэ Стандартад хэрхэн тусган оруулах эсэхийг харгалзан үзэх үедээ УСНББОУСЗ нь дараах зүйлсийг тэмдэглэсэн: (i) СТОУС 10 дахь бүрэн эрхийн талаархи хэлэлцүүлэг нь санхүүжигчийн “холбогдох үйл ажиллагаа”-д нөлөөлөх чадвар боломжид голлон чиглэдэг, ба (ii) бүрэн эрх нь хяналт оршин байхад шаардлагатай гурван элементийн зөвхөн нэг нь юм. УСНББОУСЗ нь

зохицуулалтын хяналтын талаархи хэлэлцүүлгийг бүрэн эрх ба холбогдох үйл ажиллагааны хэлэлцүүлгийн хамт оруулахаар шийдвэрлэсэн.

- ДҮ36. ҮТС 2008 дахь зохицуулалтын болон хяналтын хэлэлцүүлэг нь УСНББОУС 6-д өмнө тусгасан хэлэлцүүлэгтэй ижил төсөөтэй байгааг УСНББОУСЗ тэмдэглэсэн. ҮТС 2008-д дараах байдлаар заасан:

**Зохицуулалт ба хяналт.** Анги буюу аж үйлдвэрийн салбараар хийсэн бүлэгт хамаарах бүх байгууллагуудад мөрдөх зохицуулалт ба бие даасан нэг корпорацийн хяналт хоорондох хил заагийг шүүн тунгаахад төвөгтэй байж болох юм. Зохицуулалтаар дамжуулан хийгдэх, ялангуяа монополь ба хувьчилсан нийтийн ахуйн үйлчилгээ гэх мэт талбарууд дахь засгийн газрын оролцооны олон жишээ байдаг. Тухайн байгууллагын ерөнхий корпорацийн бодлогын хяналтыг авахгүй боловч үнэ тогтоох гэх мэт чухал талбаруудад зохицуулалтын оролцоотой байх боломжтой юм. Өндөр зохицуулалттай орчинд орох буюу тэнд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулахаар сонгох нь тухайн байгууллага хяналтын зүйл биш гэдгийг илэрхийлнэ. Зохицуулалт нь байгууллага өөрийн үйл ажиллагааг хэрхэн явуулахыг бүрэн зааварчлах байдлаар хэт хатуу байх тохиолдолд энэ нь хяналтын нэг хэлбэр байж болох юм. Хэрэв байгууллага нь улсын секторын байгууллагаас санхүүжилт авах эсэх, эсвэл түүнтэй арилжааны харилцаа үүсгэх буюу бусад байдлаар харилцах эсэхээ өөрөө шийддэг бол тухайн байгууллага нь өөрийн корпорацийн бодлогыг тодорхойлох эцсийн чадвар боломжтой бөгөөд тэрхүү улсын секторын байгууллагын хяналтанд ороогүй байна.

- ДҮ37. ҮТС 2008 нь голлох худалдан авагчийн хяналтыг авч хэлэлцсэн гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Үүнд дараах байдлаар заасан:

“Ерөнхийдөө, корпораци нь улсын секторын нөлөөллийн улмаас улсын секторын бус харилцагчтай ажил хэрэг явуулахаар сонголт хийх боломжгүй гэсэн тодорхой нотолгоо байгаа бол түүнийг улсын секторын хяналтанд байна гэж үзнэ.”

#### *Эдийн засгийн хараат байдал*

- ДҮ38. СТОУС 10-ын Б40-р параграфт “... өөр бусад ямар нэг эрхгүй тохиолдолд, хөрөнгө оруулагчаас хамаарах тухайн санхүүжигчийн эдийн засгийн хараат байдал (өөрийн гол худалдан авагчтай холбогдох нийлүүлэгчийн харилцаа гэх мэт) нь түүний хувьд уг хөрөнгө оруулагч бүрэн эрхтэй байхад хүргэхгүй” гэж заасан. Хэдийгээр эдийн засгийн хараат байдал нь хяналт үүсэхэд дангаараа хүргэхгүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн боловч эдийн засгийн хараат байдал нь бусад эрхүүдтэй холбоотойгоор улсын секторт үүсэж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Эдгээр бусад эрхүүд нь хяналт үүсгэх эсэхийг тодорхойлохын тулд тэдгээрийг үнэлэх шаардлагатай.

- ДҮ39. Улсын секторт эдийн засгийн хараат байдал нийтлэг байдаг тул УСНББОУСЗ нь эдийн засгийн хараат байдал үүсэж болох арга замуудыг авч хэлэлцэх ба эдийн засгийн хараат байдлын жишээ оруулах нь зохистой гэж үзсэн.

*Өмчлөлийн хувь оролцоонд хамаарах тусгай саналын эрх (Алтан хувьцаа)*

ДҮ40. Өмчлөлийн хувь оролцоонд хамаарах тусгай саналын эрхүүд (ихэвчлэн “алтан хувьцаа” гэж нэрлэдэг) нь хяналтын үнэлгээнд нөлөөлнө гэж энэ Стандартанд дурдах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Ийм эрхүүдийг ЗГССГА 2014-д мөн дурдсан болохыг УСНББОУСЗ тэмдэглэсэн.

*Бодит эрхүүд*

ДҮ41. Хууль ёсны хараат бус байдал нь улсын секторт нийтлэг байдаг. Хууль ёсны хараат бус байдал нь хөрөнгө оруулагчийн эрхийн үнэлгээнд нөлөөлж болох арга замуудыг үлгэрчлэн харуулахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Санхүүжигчийн хууль ёсны хараат бус байдал нь хөрөнгө оруулагч өөрийн эрхийг хэрэгжүүлэхэд учрах саад тотгор гэж үзэж болно гэдгийг энэ Стандартад (МЗУ26-р параграфт) тэмдэглэсэн. Хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах хууль ёсны бүрэн эрхийн оршин байдал нь тухайн байгууллага өөр бусад байгууллагын хяналтанд байхад дангаараа саад учруулахгүй гэдгийг бас тэмдэглэсэн (25-р параграф).

**Нэр томъёо**

ДҮ42. Стандарт нэр томъёог УСНББОУС-уудад тусгахын тулд өөрчлөлт оруулахаас гадна СТОУС 10-ын нэр томъёонд бусад олон өөрчлөлт оруулах нь зохистой байсан гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. УСНББОУС-д өөрөөр зааснаас бусад тохиолдолд нэр томъёоны талаархи энэхүү хэлэлцүүлэг нь УСНББОУС 34-УСНББОУС 38-д хамааралтай байна.

*Хөрөнгө оруулагч/Санхүүжигч*

ДҮ43. СТОУС 10 нь (i) боломжит хяналт тавигч байгууллага, энэ нь хяналт оршин байгаа эсэхийг үнэлэхийн тулд энэхүү Стандартыг мөрдөж буй байгууллага юм, ба (ii) боломжит хяналтанд буй байгууллагыг илэрхийлэхийн тулд “хөрөнгө оруулагч”, “санхүүжигч” гэсэн нэр томъёог ашигласан. Эдгээр нэр томъёо нь өмчлөлийн хувь оролцоог илэрхийлэх санхүүгийн хэрэглүүр оршин байгаа гэсэн утгаар ойлгогдож, уншигдаж болох учраас энэ Стандартын ихэнх хэсэгт тохиромжгүй гэж УСНББОУСЗ үзсэн. Улсын сектор дахь хяналтын ихэнх үнэлгээ нь ийм санхүүгийн хэрэглүүртэй холбоогүй байдаг.

ДҮ44. УСНББОУСЗ нь энэ Стандартын хүрээнд хөрөнгө оруулагч ба санхүүжигчийг илэрхийлэхэд ашиглаж болох бусад нэр томъёог харгалзан үзсэн. Нэг сонголт нь хөрөнгө оруулагчийг “боломжит хяналт тавигч байгууллага”, санхүүжигчийг “боломжит хяналтанд буй байгууллага” гэж нэрлэх явдал юм. Эдгээр хэллэгийн утга ойлгомжтой боловч энэ Стандартад бүхэлд нь хэрэглэхэд хэт нүсэр гэж УСНББОУСЗ үзсэн. УСНББОУС-ууд нь тухайн Стандартыг мөрдөж буй аж ахуйн нэгж, байгууллагыг ерөнхийдөө “байгууллага” гэж нэрлэдэг болохыг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Энэ Стандартын хувьд, тухайн Стандартыг



## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

мөрдөж буй байгууллага нь бусад байгууллагыг хянадаг, үгүй эсэхээ үнэлж буй тийм байгууллага юм (түүнийг СТОУС 10-д хөрөнгө оруулагч гэж нэрлэдэг). Энэ Стандартыг мөрдөж буй байгууллага нь бусад байгууллагыг хянадаг эсэхээ тодорхойлохын тулд энэхүү Стандартыг мөрдөж байгаа. Иймээс УСНББОУСЗ нь нөхцөл байдлаас хамааран хөрөнгө оруулагчийг “тухайн байгууллага”, харин санхүүжигчийг “бусад байгууллага”, “өөр байгууллага”, эсвэл “хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллага” гэж нэрлэхээр шийдвэрлэсэн.

ДҮ45. Энэ Стандарт нь тодорхой хөрөнгө оруулалтыг илэрхийлж байгаа бөгөөд тухайн нэр томъёог түүний ердийн утгаар ашиглаж байгаа тохиолдолд УСНББОУСЗ нь “хөрөнгө оруулагчид” гэсэн нэр томъёог хэвээр ашиглахыг зөвшөөрсөн. Энэ нь ялангуяа энэхүү Стандартын хөрөнгө оруулалтын байгууллагуудыг авч үзсэн хэсгүүдэд хамааралтай юм.

ДҮ46. Хамтарсан үйлдвэр болон хараат байгууллагууд дахь хувь оролцоог илэрхийлэх үед “хөрөнгө оруулагч” ба “санхүүжигч” гэсэн нэр томъёо тохиромжтой гэдгийг УСНББОУСЗ бас хүлээн зөвшөөрсөн.

### *Заавал биелүүлэх хэлцэл*

ДҮ47. СТОУС 10 дахь “гэрээний тохиролцоо” гэсэн ихэнх хэллэгийг “заавал биелүүлэх хэлцэл” нэр томъёогоор орлуулахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Зарим улс орны хувьд, УСНББОУС-ыг мөрдөж буй байгууллагууд нь гэрээ байгуулах бүрэн эрхгүй байж болох боловч заавал биелүүлэх хэлцэл хийх эрх мэдэлтэй байж болно гэдгийг энэхүү өөрчлөлт харгалзан үзсэн. Түүнчлэн, энэ Стандартын зорилгын хувьд заавал биелүүлэх хэлцэл нь хууль тогтоох буюу засаглах бүрэн эрхээс үүсэх эрхүүдийг өөртөө агуулсан байвал зохино гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Энэ Стандартад ашигласан заавал биелүүлэх хэлцэл нэр томъёог санхүүгийн хэрэглүүрийн стандартуудад ашигласан уг нэр томъёоноос зориудаар илүү өргөн хүрээтэйгээр тодорхойлсон. Харин санхүүгийн хэрэглүүрийн стандартуудад уг нэр томъёог гэрээтэй ижил төсөөтэй эрхүүд болон арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудтай холбоотойгоор ашигладаг.

### *Өгөөж*

ДҮ48. Улсын секторт, ялангуяа уг хяналтанд буй байгууллагад санхүүгийн хөрөнгө оруулалтгүй үед хяналтын харилцааны оршин байдлыг харгалзан үзвэл “өгөөж” нэр томъёо нь “үр өгөөж” нэр томъёоноос илүү тохиромжтой гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. “Үр өгөөж” гэсэн нэр томъёог санхүүгийн өгөөжид хэт ач холбогдол өгөх байдлаар харгалзан үзэж болно, харин улсын секторт өгөөж нь санхүүгийн гэхээсээ илүүтэйгээр санхүүгийн бус байх магадлалтай гэж УСНББОУСЗ үзсэн. Хөрөнгө оруулалтын байгууллагуудын хувьд “үр өгөөж” гэсэн нэр томъёог хэвээр хадгалсан.

ДҮ49. УСНББОУСЗ нь дараах зүйлсийг гүйцэтгэхийн тулд СТОУС 10-д засвар өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн:

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- (а) Улсын сектор дахь хяналтын олон үнэлгээ нь санхүүгийн бус өгөөжийн үнэлгээтэй холбоотой гэдгийг онцлон тэмдэглэх;
- (б) Өгөөж нь зэрэг эсвэл сөрөг төлөв байдалтай байж болно гэдгийг дурдах; ба
- (в) Улсын секторын хүрээнд өгөөжийн жишээг тусган оруулах.

ДҮ50. Байгууллага нь бусад байгууллагуудыг хянаж буй эсэх талаар анхны үнэлгээг хийхэд жишээнүүд онцгой ач холбогдолтой гэж үзсэн тул УСНББОУСЗ нь энэ Стандартын үндсэн хэсэгт өгөөжийн талаархи жишээ оруулахыг зөвшөөрсөн.

ДҮ51. УСНББОУС 35 дахь хяналтын тодорхойлолтонд “хувьсах өгөөж”-ийг дурдсан бөгөөд уг ойлголт ухагдахууныг энэ Стандартад нийтэд нь ашигласан. Тогтмол буюу тодорхой байж болох өгөөжид энэ Стандартыг хэрхэн мөрдөхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. НББОУСЗ нь энэ асуудлыг дэлгэрэнгүй авч үзсэн бөгөөд тогтмол гэж харагдаж буй өгөөж нь тухайн байгууллагад гүйцэтгэлийн эрсдэл учруулж болох учраас үнэн хэрэгтээ хувьсах байж болно гэдгийг харуулахын тулд жишээ оруулсан гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь НББОУСЗ-ийн жишээнүүд санхүүгийн өгөөжтэй холбоотой гэдгийг тэмдэглэсэн бөгөөд санхүүгийн бус өгөөжийн жишээг МЗУ58-р параграфт тусган оруулахыг зөвшөөрсөн.

### Тайлагналын нийтлэг өдөр

ДҮ52. Хяналт тавигч байгууллага болон түүний хяналтанд буй байгууллагуудын тайлант үеийн эцсийн өдрүүдийн хоорондох зөрүүд хугацааны хязгаар тогтоох эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхэд ашигласан санхүүгийн тайлан нь нэг ижил тайлангийн өдөртэй байх буюу ийм практик боломжгүй тохиолдолд хяналтанд буй байгууллагуудын хамгийн сүүлийн санхүүгийн тайлангуудад залруулга хийхийг СТОУС 10-аар шаарддаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Түүнчлэн, СТОУС 10 нь тайлангийн өдрүүдийн хоорондох зөрүүг гурван сараас хэтрэхгүй байхаар хязгаарласан. Байгууллагууд нь тайлагналын өөр өөр өдрүүдтэй байх бөгөөд тэдгээр өдрүүдийг өөрчлөх боломжгүй тийм тохиолдол улсын секторт үүсэж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь хугацааны зөрүүний хувьд гурван сарын хязгаар тогтоохгүй байхыг зөвшөөрсөн.

### Хэрэгжүүлэлтийн асуудлууд

ДҮ53. Хариулт ирүүлсэн олон хүмүүс нь ялангуяа нийт засгийн газрын санхүүгийн тайлан бэлтгэх гэх мэт хяналтанд буй маш олон байгууллагуудтай тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхэд хүндрэлтэй байх талаар саналаа илэрхийлсэн. Нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулж буй ихэнх улс орнууд нь үүнтэй адилтгах хүндрэлтэй тулгардаг гэдгийг тэмдэглэхийн хамтаар УСНББОУСЗ нь ийм практик хүндрэлтэй байдлыг хүлээн зөвшөөрсөн. Ийм улс орнуудын хувьд, нэгтгэж буй байгууллагууд нь нарийн цогц байдал ба нэгтгэлийн хүндрэлийг даван туулахын тулд

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

хялбаршуулсан стратеги ашигладаг. Ийм стратегид дараах зүйлс хамаарна:

- (а) Материаллаг байх магадлалтай байгууллагуудад эхлээд анхаарал хандуулахын хамтаар янз бүрийн ангиллын байгууллагуудын хувьд хяналтын оршин байдлыг үе шаттайгаар үнэлэх.
- (б) Материаллаг бус байж магадлалтай, хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэхгүй (буюу нэгтгэлийг хойшлуулах).
- (в) Байгууллагуудын хоорондох үлдэгдэл ба ажил гүйлгээний талаархи мэдээллийг олж авах өртөг-өгөөжийн арга замыг тодорхойлох.
- (г) Байгууллагуудын хоорондох материаллаг бус үлдэгдэл ба ажил гүйлгээг устгаж цэвэрлэхгүй байх.
- (д) Бүх байгууллагуудын хувьд тодруулгыг бүгдийг хийх шаардлагатай эсэхийг харгалзан үзэх.

ДҮ54. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх үед материаллаг байдлыг ашиглах талаархи тусгай заавар удирдамжаар хангах эсэхийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн боловч санхүүгийн тайлагналын стандартын хувьд энэ нь тохиромжгүй гэж дүгнэсэн.

### **Хөрөнгө оруулагч ба түүний хараат байгууллага, хамтарсан үйлдвэрийн хоорондох хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлт**

ДҮ55. Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани буюу хамтарсан үйлдвэрийн хоорондох ажил гүйлгээний хувьд хэсэгчилсэн олз, гарз хүлээн зөвшөөрөх шаардлагуудыг СТОУС 3, *Бизнесийн Нэгдэл*-д тодорхойлсончлон, *бизнесийг бүрдүүлдэггүй* зөвхөн тийм хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлтээс үүсэх олз, гарзад мөрддөг болгохын тулд НББОУСЗ нь УСНББОУС 35-ыг боловсруулж байх энэ үед СТОУС 10 болон НББОУС 28-д нэмэлт өөрчлөлт оруулах үүднээс саналын төсөлд санал авч байсан. НББОУСЗ нь *Хөрөнгө Оруулагч ба түүний Хараат Компани эсвэл Хамтарсан Үйлдвэрийн Хоорондох Хөрөнгийн Борлуулалт буюу Хөрөнгөөрх Хувь Нийлүүлэлт* (СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)-ийг 2014 оны 9 дүгээр сард гаргасан. Бүрэн буюу хэсэгчилсэн олз, гарзын хүлээн зөвшөөрөлтийг улсын секторын нэгдлүүдэд хамаарах стандартын түвшний шаардлагуудын төслийг боловсруулах хүрээнд харгалзан үзэх нь илүү тохиромжтой гэсэн үндэслэлээр УСНББОУСЗ нь эдгээр нэмэлт өөрчлөлтөөр илэрхийлэгдэх шаардлагуудыг УСНББОУС 35 ба УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-д тусган оруулахгүй байхыг зөвшөөрсөн.

ДҮ56. СТ 60, *Улсын Секторын Нэгдэл*-ийг боловсруулж байх үедээ УСНББОУСЗ нь хяналтанд өмнө байсан байгууллагын хяналтаа алдалтыг хөрөнгө оруулагчийн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр болгон хэрхэн тайлагнах талаархи заавар удирдамжийг тусган оруулах эсэхийг дахин харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь НББОУСЗ-өөс гаргасан *Хөрөнгө Оруулагч ба түүний Хараат Компани эсвэл Хамтарсан Үйлдвэрийн*

*Хоорондох Хөрөнгийн Борлуулалт буюу Хөрөнгөөрх Хувь Нийлүүлэлт* (СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)-д тусгасан заавар удирдамжийг нягталж үзсэн. Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани буюу хамтарсан үйлдвэрийн хоорондох ажил гүйлгээний хэсэгчилсэн олз, гарз болох байсан уг НББОУС3-ийн нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэв УСНББОУС 35-д оруулан мөрдвөл түүний үр нөлөөг *үйл ажиллагааг агуулдаггүй* тэрхүү өмнө нь хяналтанд байсан байгууллагын хяналтыг алдсанаас үүсэх олз, гарзад зөвхөн хамааруулан мөрдөнө. УСНББОУС3 нь НББОУС3-ийн арга хандлагаас гажих, улсын секторын ямар нэг тусгай учир шалтгааныг тогтоогоогүй. Иймээс УСНББОУС3 нь энэхүү заавар удирдамжийг (СТ 60 дахь нэр томъёо ба тодорхойлолттой нийцүүлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулсан) УСНББОУС 35-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

ДҮ57. 2015 оны 12 дугаар сард НББОУС3 нь *Хөрөнгө Оруулагч ба түүний Хараат Компани эсвэл Хамтарсан Үйлдвэрийн Хоорондох Хөрөнгийн Борлуулалт буюу Хөрөнгөөрх Хувь Нийлүүлэлт* (СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)-д тусгасан заавар удирдамжийн хэрэгжилтийг хойшлуулсан. Яагаад гэвэл, НББОУС3 нь өмчийн нягтлан бодох бүртгэлийн талаархи өөрийн төслийн нэг хэсэг болгон энэхүү талбарт цаашдын судалгаа хийж байсан бөгөөд богино хугацааны дотор өөрсдийн нягтлан бодох бүртгэлд хоёр удаа өөрчлөлт оруулахыг аж ахуйн нэгжүүдээс шаардахыг хүсээгүй. Хүчин төгөлдөр болох хугацааг хойшлуулахдаа НББОУС3 нь илүү сайн санхүүгийн тайлагналын мөрдөлтөнд саад учруулахыг хүсээгүй тул уг заавар удирдамжийн дурдсан хугацаанаас өмнө мөрдөлтийг зөвшөөрсөн хэвээр байсан. УСНББОУС3 нь энэхүү заавар удирдамжийн хэрэгжилтийг хойшлуулах НББОУС3-ийн шийдвэрийг нягталж үзсэн. УСНББОУС3 нь НББОУС3-ийн арга хандлагаас гажих, улсын секторын ямар нэг тусгай учир шалтгааныг тогтоогоогүй. Иймээс УСНББОУС3 нь энэхүү заавар удирдамжийг УСНББОУС 35-д тусган оруулж, УСНББОУС3-өөс тодорхойлсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг зөвшөөрсөн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 35-д хийсэн хянан засварлалт**

ДҮ58. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох*

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

*Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.*

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.


## Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 35-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

### Бусад байгууллагатай холбогдох харилцааны шинж төрөл

ХЗУ1. Бусад байгууллага дахь төрөл бүрийн оролцооны тайлагналыг доорх схемд хураангуйлан харуулав.

#### Блок схем 1: Бусад байгууллага дахь оролцооны хэлбэрүүд



## Үлгэрчилсэн жишээ

*Эдгээр жишээ нь УСНББОУС 35-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

ҮЖ1. Энэ Хавсралт дахь жишээнүүд нь таамагласан нөхцөл байдлуудыг илэрхийлнэ. Хэдийгээр эдгээр жишээний зарим төлөв байдал нь бодит нөхцөл байдалд илрэн гарч болох боловч УСНББОУС 35-ыг мөрдөх үедээ тухайн тодорхой хэв загварын бүх баримт материал болон нөхцөл байдлыг үнэлэх шаардлагатай байдаг.

### Бүрэн эрх (МЗУ9-МЗУ56-р параграф)

ҮЖ2. Энэ Стандартын зорилгын хувьд бүрэн эрх оршин буй эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулна.

#### Жишээ 1

Мужийн засгийн газар нь орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааг хэсэгчлэн санхүүжүүлдэг. Энэ санхүүжилтийн зарим хэсгийг тодорхой арга хэмжээнд зарцуулахыг шаарддаг. Орон нутгийн засаг захиргаа нь зөвлөлтэй бөгөөд түүнийг тухайн орон нутгийн иргэд дөрвөн жил тутамд сонгодог. Тус зөвлөл нь орон нутгийн засаг захиргааны нөөцийг тухайн орон нутгийн иргэдийн ашиг тусын төлөө хэрхэн ашиглан зарцуулахыг шийдвэрлэдэг. Орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаа нь олон талтай бөгөөд үүнд номын сангийн үйлчилгээ, амралт чөлөөт цагийг өнгөрүүлэх байгууламжаар хангалт, хог хаягдал ба бохир усны менежмент, түүнчлэн барилга байгууламжийн, эрүүл мэндийн болон аюулгүй байдлын дүрэм журмын хэрэгжүүлэлт хамаардаг. Эдгээр үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн засаг захиргааны холбогдох үйл ажиллагаа юм. Эдгээр олон үйл ажиллагаа нь мужийн засгийн газрын ашиг сонирхолтой бас нийцдэг.

Хэдийгээр тухайн орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааг хэсэгчлэн санхүүжүүлдэг боловч мужийн засгийн газар нь уг орон нутгийн засаг захиргааны холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхгүй байдаг. Холбогдох үйл ажиллагааны талаархи орон нутгийн засаг захиргааны эрх нь мужийн засгийн газар хяналт тогтооход саад учруулахгүй.

### Зохицуулалтын хяналт (МЗУ12-р параграф)

ҮЖ3. Доорх жишээнүүд зохицуулалтын хяналтын янз бүрийн хэлбэрийг дүрслэн харуулав. Энэхүү зохицуулалтын хяналтын аль ч хэлбэр нь энэ Стандартын зорилгоор холбогдох үйл ажиллагаанд хяналт бий болгоогүй. Гэвч зохицуулалтын хяналтын улмаас энэ Стандартын зорилгоор холбогдох үйл ажиллагаанд хяналт тогтоосон нөхцөл байдал үүсэхийг эдгээр жишээнүүд нь үгүйсгэхгүй.

**Жишээ 2**

Бохирдлын хяналтын эрх бүхий байгууллага нь байгаль орчны хууль тогтоомжийг даган мөрдөөгүй байгууллагуудын үйл ажиллагааг хаах бүрэн эрхтэй.

Ийм бүрэн эрхийн оршин байдал нь холбогдох үйл ажиллагаанд хамаарах бүрэн эрхийг орлохгүй.

**Жишээ 3**

Тухайн хот нь түргэн хоолны газруудын байршлыг хязгаарлах эсвэл бүхэлд нь хориглон хязгаарлах бүсчлэлийн хууль тогтоомж гаргах бүрэн эрхтэй.

Ийм бүрэн эрхийн оршин байдал нь түргэн хоолны газруудын холбогдох үйл ажиллагаанд хамаарах бүрэн эрхийг орлохгүй.

**Жишээ 4**

Төв Засгийн газар нь монопольд зохицуулалтын хяналт тавих бүрэн эрхтэй. Засгийн газрын бүрэн өмчлөлт агентлаг нь ийм зохицуулалтын хяналтын зүйл болох монополийг зохицуулах бүрэн эрхтэй бөгөөд цахилгаан түгээдэг байгууллагуудын хувьд үнийн дээд хэмжээг тогтоодог. Төв Засгийн газар нь цахилгаан түгээгч байгууллагуудад өмчлөлийн хувь оролцоогүй ба тэдгээр цахилгаан түгээгч байгууллагуудаас санхүүгийн өгөөж хүртдэггүй. Төв Засгийн газар болон Засгийн газрын агентлагийн аль аль нь зохицуулалтын хяналтыг хэрэгжүүлэх бүрэн эрхийн үр дүнд хяналт тогтоодоггүй. Аливаа бусад бүрэн эрхийг тусад нь үнэлэх шаардлагатай.

**Жишээ 5**

Тоглоомонд Хяналтын тавих Зөвлөл (ТХЗ) нь тухайн мужид казино болон бусад тоглоомыг зохицуулж, мужийн тоглоомын хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг засгийн газрын агентлаг юм. ТХЗ нь тухайн муж дахь тоглоомын үйл ажиллагаа эрхлэлтийг зохицуулах дүрэм, журмыг томъёолон гаргах үүрэг хүлээдэг. Дээрх дүрэм, журам нь хууль тогтоомжид үндэслэдэг. Хууль тогтоох байгууллага нь уг хууль тогтоомжийг батлан гаргах бөгөөд тоглоомын талаархи тухайн мужийн ерөнхий бодлогыг тогтоодог; харин тоглоомын газар, түүний эзэд, ажиллагчид, нийлүүлэгчдийн даган биелүүлэх ёстой нарийвчилсан шаардлагуудыг уг дүрэм, журамд заадаг. Энэхүү дүрэм, журам нь өргөн хүрээтэй үйл ажиллагааг, үүн дотроо тусгай зөвшөөрөл, нягтлан бодох бүртгэлийн систем, казиногийн тоглолтын дүрэм, аудитын үйл ажиллагааг зохицуулдаг.

ТХЗ нь мөн тоглоомын газрууд, тэдгээрийн өмчлөл, ажиллагчид, нийлүүлэгчдэд тусгай зөвшөөрөл олгох эсвэл татгалзах бүрэн эрхтэй байдаг. Тусгай зөвшөөрөл авахын тулд өргөдөл гаргагч нь сайн зан



төлөвтэй, үнэнч, шударга гэдгээ батлан харуулах ёстой. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягт нь хувь хүний дэлгэрэнгүй мэдээллийг ихэвчлэн шаардсан байдаг. Хүсэж буй тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран өөрийн өмнөх бизнесийн харилцаа, ажил эрхлэлтийн түүх, гэмт хэргийн бүртгэл, санхүүгийн тогтвортой байдлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулахыг өргөдөл гаргагчаас бас шаардаж болох юм.

Дүрэм, журам нь тоглоомын газрууд үйл ажиллагаагаа хэрхэн явуулахад нөлөө үзүүлдэг боловч ТХЗ нь тэдгээр тоглоомын газруудын холбогдох үйл ажиллагааны (энэ Стандартад тодорхойлсон) хувьд бүрэн эрхгүй байдаг. Дүрэм, журмуудыг бүх тоглоомын газруудад мөрдөх бөгөөд тоглоомын газар бүр нь тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хүсэх эсвэл үгүй эсэх сонголттой байдаг. Тоглоомын тухай хууль тогтоомж, журмын зорилго нь тэдгээр тоглоомын газруудад хяналтын хувь оролцоог бий болгох бус, харин олон нийтийн эрх ашгийг хамгаалахад оршино.

*Холбогдох үйл ажиллагаанууд ба холбогдох үйл ажиллагаануудын удирдан чиглүүлэлт (МЗУ13-МЗУ15 -р параграф)*

ҮЖ4. Тухайн байгууллага нь энэ Стандартын зорилгын хувьд бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхтэй эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

#### **Жишээ 6**

А ба Б байгууллагууд нь эмчилгээний бүтээгдэхүүнийг хөгжүүлэн бий болгож, зах зээлд гаргахын тулд В гэсэн өөр байгууллагыг үүсгэн байгуулсан. А байгууллага нь уг эмчилгээний бүтээгдэхүүнийг хөгжүүлэн бий болгох ба зохицуулах байгууллагын зөвшөөрлийг олж авах үүрэг хүлээсэн. Энэхүү үүрэг нь бүтээгдэхүүний хөгжүүлэлт болон зохицуулах байгууллагын зөвшөөрлийг олж авахтай холбоотой бүх шийдвэрийг дангаараа гаргах чадвар боломжийг агуулсан байдаг. Зохицуулах байгууллага нь тухайн бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгомгоц Б байгууллага нь түүнийг үйлдвэрлэж, зах зээлд гаргах юм. Б байгууллага нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба зах зээлд гаргалттай холбоотой бүх шийдвэрийг дангаараа гаргах чадвар боломжтой юм. Хэрэв уг эмчилгээний бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, зохицуулах байгууллагын зөвшөөрлийг авах, түүнчлэн үйлдвэрлэх, зах зээлд гаргах бүх үйл ажиллагаа нь холбогдох үйл ажиллагаа мөн бол А ба Б байгууллага нь В байгууллагаас хүртэх өгөөжид хамгийн их нөлөө үзүүлэх тэдгээр үйл ажиллагаануудыг удирдан чиглүүлэх чадвар боломжтой эсэхээ тус бүрдээ тодорхойлох шаардлагатай юм. Иймээс уг эмчилгээний бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, зохицуулах байгууллагын зөвшөөрлийг авах эсвэл түүнийг үйлдвэрлэх, зах зээлд гаргах ажиллагаа нь В байгууллагаас хүртэх өгөөжид хамгийн их нөлөө үзүүлэх үйл ажиллагаа мөн эсэх, түүнчлэн тэрхүү үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвар боломжтой эсэхээ А ба Б байгууллага нь тус бүрдээ харгалзан үзэх

шаардлагатай. Аль байгууллага нь бүрэн эрхтэй эсэхийг тодорхойлохдоо, А ба Б байгууллага нь дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- (а) В байгууллагын зорилго ба бүтэц;
- (б) В байгууллагын ашиг, орлого, үнэ цэнэ, түүнчлэн уг эмчилгээний бүтээгдэхүүний үнэ цэнийг тодорхойлох хүчин зүйлс;
- (в) Дээрх (б)-д дурдсан хүчин зүйлстэй холбоотойгоор шийдвэр гаргах тэдгээрийн бүрэн эрх нь В байгууллагын гүйцэтгэл, үр дүнд үзүүлэх үр нөлөө; ба
- (г) В байгууллагаас хүртэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд тэдгээрийн хүлээх эрсдэл.

Энэхүү жишээний хувьд байгууллагууд нь мөн дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- (а) Зохицуулах байгууллагын зөвшөөрлийг олж авахтай холбоотой тодорхойгүй байдал ба шаардлагатай хүчин чармайлт (эмчилгээний бүтээгдэхүүний амжилттай хөгжүүлэлт ба зохицуулах байгууллагын зөвшөөрөл олж авалтын талаархи тэдний баримт бүртгэлийг харгалзан үзэх); ба
- (б) Хөгжүүлэлтийн үе шат амжилттай болмогц уг эмчилгээний бүтээгдэхүүнийг аль байгууллага нь хянах эсэх.

#### **Жишээ 7**

Хөрөнгө оруулалтын хэрэгслийг тухайн байгууллагын (өрийн хөрөнгө оруулагчийн) эзэмшиж буй өрийн хэрэглүүр болон олон тооны бусад хөрөнгө оруулагчдын эзэмшиж байгаа өмчийн хэрэглүүрээр үүсгэн бий болгож, санхүүжүүлсэн. Уг өмчийн багц нь хөрөнгө оруулалтын хэрэгслийн (санхүүжигчийн) эхний алдагдлуудыг хариуцах ба аливаа үлдэх өгөөжийг авах зорилготой байдаг. Өмчийн 30 хувийг эзэмшдэг нэг хөрөнгө оруулагч нь мөн уг хөрөнгийн менежер юм. Хөрөнгө оруулалтын хэрэгсэл нь санхүүгийн хөрөнгийн багц худалдан авахад өөрийн орлогыг ашигладаг бөгөөд тухайн хөрөнгийн үндсэн дүнгийн болон хүүний төлбөрийн боломжит үл биелүүлэлттэй холбоотойгоор уг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд зээлийн эрсдэл үүсдэг. Ийм санхүүгийн хөрөнгийн шинж төрлөөс хамааран, түүнчлэн энэ хөрөнгө оруулалтын хэрэгслийн эхний алдагдлуудыг өмчийн багц хариуцах тул тухайн багц дахь хөрөнгүүдийн боломжит үл биелүүлэлттэй холбоотой зээлийн эрсдэл хамгийн бага байх хөрөнгө оруулалт гэж уг ажил гүйлгээг тэрхүү өрийн хөрөнгө оруулагчид танилцуулан гаргасан. Хөрөнгө оруулалтын хэрэгслийн хөрөнгийн багцын удирдлага, үүн дотроо тухайн багцын заавар удирдамжийн хүрээнд санхүүгийн хөрөнгүүдийг сонгох, худалдан авах, данснаас хасах талаархи шийдвэрүүд болон багцын аль нэг хөрөнгийн үл биелүүлэлтийн үеийн удирдлага нь уг хөрөнгө оруулалтын хэрэгслийн өгөөжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Үл биелүүлэлт нь тухайн багцын үнэ цэнийн тохиролцсон хувь хэмжээнд хүрэх (өөрөөр хэлбэл, багцын үнэ цэнэ нь тухайн хөрөнгө оруулалтын хэрэгслийн

өмчийн багцыг ашиглаж дуусах үе) хүртэл хөрөнгийн менежер нь эдгээр бүх үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ. Энэ үеэс эхлэн гуравдагч итгэмжлэгдсэн этгээд нь уг өрийн хөрөнгө оруулагчийн зааварчилгааны дагуу хөрөнгийг удирдан чиглүүлнэ. Хөрөнгө оруулалтын хэрэгслийн хөрөнгийн багцыг удирдан зохицуулах нь тэрхүү хөрөнгө оруулалтын хэрэгслийн холбогдох үйл ажиллагаа юм. Үл биелүүлсэн хөрөнгүүд нь тухайн багцын үнэ цэнийн тохиролцсон хувь хэмжээнд хүрэх хүртэл хөрөнгийн менежер нь холбогдох үйл ажиллагаануудыг удирдан чиглүүлэх чадвар, боломжтой байна; үл биелүүлсэн хөрөнгүүдийн үнэ цэнэ нь багцын үнэ цэнийн тэрхүү тохиролцсон хувь хэмжээнээс хэтэрсэн үед өрийн хөрөнгө оруулагч нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвар, боломжтой байна. Хөрөнгийн менежер болон өрийн хөрөнгө оруулагч нь тухайн хөрөнгө оруулалтын хэрэгслийн өгөөжид хамгийн ихээр мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үйл ажиллагаануудыг өөрөө удирдан чиглүүлэх чадвар, боломжтой эсэхээ тус тусдаа тодорхойлох шаардлагатай, үүнд тэрхүү хөрөнгө оруулалтын хэрэгслийн зорилго ба бүтэц, түүнчлэн өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд тал тус бүрийн хүлээх эрсдлийг харгалзан үзнэ.

*Бусад байгууллагын бүрэн эрхийг тухайн байгууллагад өгдөг эрхүүд (МЗУ16-МЗУ28-р параграф)*

ҮЖ5. Тухайн байгууллага нь энэ Стандартын зорилгын хувьд бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхтэй эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

#### **Жишээ 8**

Засгийн газрын орон сууцны агентлаг нь хямд өртөг зардалтай орон байраар хангах нийтийн орон сууцны хөтөлбөрийг гаргасан. Уг хөтөлбөр нь нэгдсэн холбоотой байгуулсан хэлцлийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Холбооны цорын ганц үйл ажиллагаа нь нийтийн орон сууцны байгууламжийг удирдан зохицуулах явдал юм. Тус холбоо нь өмчлөлийн хэрэглүүрийг эзэмшдэггүй.

Тус холбооны холбогдох үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна:

- Орон сууцны өргөдөл гаргагчдыг шалгах ба сонгох;
- Орон сууцны хөтөлбөрийн өдөр тутмын үйл ажиллагаа;
- Орон сууц ба нийтийн эзэмшлийн байгууламжийн засвар үйлчилгээ; ба
- Орон сууцны байгууламжийн сайжруулалт ба өргөтгөл.

Тус холбооны удирдах зөвлөл нь 16 гишүүнтэй бөгөөд үүнээс найман гишүүнийг Засгийн газрын орон сууцны агентлагаас томилдог (буюу

чөлөөлдөг). Засгийн газрын орон сууцны агентлагаас томилогдсон гишүүдийн дундаас удирдах зөвлөлийн даргыг тус удирдах зөвлөл томилдог бөгөөд санал тэнцсэн үед даргын саналаар шийдвэрлэх боловч уг саналыг бараг хэрэгжүүлдэггүй. Удирдах зөвлөл нь тогтмол хуралдаж, тус холбооны удирдлагаас ирүүлсэн тайланг хянадаг. Эдгээр тайланд үндэслэн удирдах зөвлөл нь удирдлагын шийдвэрийг баталж эсвэл хүчингүй болгож болно. Түүнчлэн, удирдах зөвлөл нь сул чөлөөтэй орон зай ба орон сууцны эрэлт хэрэгцээг нягталж үзсэний эцэст нэмэлт орон сууц барихад цаашид хөрөнгө оруулах, томоохон засвар үйлчилгээ хийх гэх мэт гол чухал асуудлуудын талаархи шийдвэрийг гаргадаг.

Засгийн газрын орон сууцны агентлаг нь орон сууцны байгууламжийн байрлаж буй газрыг өмчилдөг бөгөөд тус холбоог байгуулагдсан цагаас хойш түүнд хувь нийлүүлсэн капитал ба үйл ажиллагааны санжүүжилтийг оруулж ирсэн. Харин холбоо нь орон сууцны байгууламжийг өмчилдөг.

Тус холбоо нь орон сууцны байгууламжийн үйл ажиллагааны үр дүн болох аливаа ашгийг өөртөө үлдээдэг бөгөөд дүрэмд заасны дагуу Засгийн газрын орон сууцны агентлагт санхүүгийн шууд өгөөж олгож болохгүй юм. Дээрх нөхцөл байдлыг доор дурдсан 8А ба 8Б жишээнд ашиглана. Жишээ бүрийг тусад нь авч үзнэ.

#### **Жишээ 8А**

Дээр дурдсан баримт материал ба нөхцөл байдлыг харгалзан үзвэл Засгийн газрын орон сууцны агентлаг нь тус холбоог хянадаг.

Засгийн газрын орон сууцны агентлаг нь өөрийн эрхийг хэрэгжүүлэх сонголт хийсэн эсэхээс үл хамааран тухайн холбооны холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар боломжийг түүнд олгох эрхтэй байна.

Засгийн газрын орон сууцны агентлаг нь удирдах зөвлөлийн найман гишүүнийг томилдог бөгөөд тэдгээрийн нэгийг даргаар сонгодог, дарга нь санал тэнцсэн үед давуу саналтай байдаг. Иймээс Засгийн газрын орон сууцны агентлаг нь өөрийн бодит эрхүүдийг хэрэгжүүлэх сонголт хийсэн эсэхээс үл хамааран тухайн холбооны холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар боломжийг түүнд олгох бодит эрхүүдээр дамжуулан уг холбооны хувьд бүрэн эрхтэй байдаг.

Мөн Засгийн газрын орон сууцны агентлаг нь тус холбоон дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хүртэх эрхтэй буюу өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг. Засгийн газрын орон сууцны агентлаг нь хямд өртөг зардалтай орон байрны хэрэгцээ шаардлагыг хангах өөрийн нийгмийн зорилтыг тус холбоогоор дамжуулан хэрэгжүүлснээр санхүүгийн бус өгөөж хүртэж байна. Хэдийгээр Засгийн газрын орон сууцны агентлаг нь санхүүгийн шууд өгөөж хүртэж болохгүй боловч нийтийн орон сууцны хөтөлбөрийн хувьд санхүүгийн өгөөжийг

хэрхэн ашиглахыг удирдан чиглүүлэх өөрийн чадвар боломжоор дамжуулан шууд бус өгөөж хүртдэг.

Мөн Засгийн газрын орон сууцны агентлаг нь эцсийн хяналтын шалгуурыг хангадаг. Засгийн газрын орон сууцны агентлаг нь удирдах зөвлөлд томилогдсон гишүүдээр дамжуулан тус холбооноос хүртэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэх өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломжтой байна.

Засгийн газрын орон сууцны агентлаг нь хяналтын гурван шалгуурыг бүгдийг хангаж байгаа ба иймээс тухайн засгийн газрын орон сууцны агентлаг нь тус холбоог хянаж байна.

#### **Жишээ 8Б**

Энэхүү жишээнд доор дурдсанаас бусад тохиолдолд Жишээ 8А-гийн өгөгдлийг ашигласан:

- (а) Удирдах зөвлөлийн гишүүдийг томилох эрхийг уг засгийн газрын орон сууцны агентлагад олгодоггүй олон нийтийн нэр дэвшүүлэлтийн болон санал хураалтын процессоор дамжуулан тус холбооны удирдах зөвлөлийг сонгодог; ба
- (б) Тус холбооны удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрүүдийг Засгийн газрын орон сууцны агентлаг хянадаг бөгөөд тус холбоонд зөвлөгөө өгч болох юм.

Дээр дурдсан, уг хянан засварласан баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзвэл, Засгийн газрын орон сууцны агентлаг нь тус холбоонд хамаарах бодит эрхгүй ба иймээс уг холбооны хувьд бүрэн эрхгүй байна.

Бага өртөг зардалтай нийтийн орон байртай холбоотой Засгийн газрын орон сууцны агентлагийн нийгмийн зорилтуудыг хангаж байгаа бөгөөд ингэснээр санхүүгийн бус өгөөжийг шууд хүртсээр байх болно. Гэвч зорилттой нийцэх нь бусад байгууллагыг тус байгууллага хянадаг гэж дүгнэхэд хангалтгүй юм (36-р параграфыг үзнэ үү).

Засгийн газрын орон сууцны агентлаг нь бүрэн эрхгүй, иймээс тухайн агентлагийн өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөөлөх бүрэн эрхийг ашиглах чадвар боломжгүй байна. Засгийн газрын орон сууцны агентлаг нь хяналтын гурван шалгуурын хоёрыг хангаж чадахгүй учраас уг засгийн газрын орон сууцны агентлаг нь тус холбоог хянахгүй.

#### **Жишээ 9**

Засгийн газар нь удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийг томилох ба чөлөөлөх эрхтэй. Энэхүү бүрэн эрхийг өмнөх засгийн газрууд ашиглаж байсан. Одоогийн засгийн газар нь удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцдог гэж харагдахгүй хүсэхгүй байгаа улс төрийн шалтгааны улмаас бүрэн эрхийг хэрэгжүүлээгүй. Энэ тохиолдолд

засгийн газар нь хэдийгээр түүнийг ашиглахгүй байх сонголт хийсэн боловч бодит эрхтэй хэвээр байна.

#### **Жишээ 10**

Орон нутгийн засаг захиргаа нь өөрт шаардлагатай хэмжээнээс илүүдэл газрыг эзэмших бодлоготой бөгөөд хямд орон байранд зориулан газрыг ашиглуулахад анхаарал хандуулдаг. Барьсан орон байр нь хямд бөгөөд тухайн орон нутгийн орон байрны хэрэгцээ шаардлагыг хангах боломжтой байлгахын тулд тус орон нутгийн засаг захиргаа нь нөхцөл, болзлыг тогтоодог.

Энэхүү бодлогын дагуу тухайн орон нутгийн засаг захиргаа нь 20 ширхэг хямд орон байр бий болгохын тулд орон сууцны холбоонд тус газрын нэг хэсгийг 1 ТН-ээр борлуулсан. Уг газрын үлдсэн хэсгийг нээлттэй зах зээлийн үнээр хувийн өмчийн хөгжүүлэгч компанид борлуулсан.

Орон нутгийн засаг захиргаа ба орон сууцны холбооны хооронд байгуулсан гэрээнд уг газрыг ямар зорилгоор ашиглах, орон сууцны барилгын ажлын чанар, явцын тайлагнал ба гүйцэтгэлийн удирдлагын шаардлагууд, ашиглаагүй газрыг буцааж өгөх процесс, маргаан шийдвэрлэлтийг тусгайлан заасан байдаг. Хямд орон сууцаар хангах уг орон нутгийн засаг захиргааны бодлоготой нийцсэн тийм арга замаар тухайн газрыг ашиглах ёстой.

Орон сууцны холбооны чанарын баталгаажуулалт ба санхүүгийн удирдлагын процесстэй холбоотой шаардлагуудыг уг гэрээнд мөн тусгасан. Уг орон сууцны холбоо нь бүтээн байгуулалтыг хийх чадвар боломжтой ба эрх мэдэлтэй гэдгээ батлан харуулах ёстой. Үйлчлүүлэгчийн тодорхой бүлгийн хүрээнд хэрэгцээ шаардлагыг тогтвортой байдлаар хангахын тулд орон нутгийн засаг захиргааны нөөцийг тухайн орон сууцны холбооны нөөцтэй нэгтгэн холбосноор нэмэгдсэн үнэ цэнийг бий болгож чадна гэдгээ бас харуулах ёстой.

Орон сууцны холбооны удирдах зөвлөлийг тухайн орон сууцны холбооны гишүүд томилдог. Тухайн орон нутгийн засаг захиргаа нь уг удирдах зөвлөлд төлөөлөлтэй байдаггүй.

Дээр дурдсан, баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзвэл, Засгийн газрын орон сууцны агентлаг нь тус холбооны холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх хангалттай бүрэн эрхгүй, иймээс уг холбоог хянахгүй. Орон нутгийн засаг захиргаа нь хямд өртөг зардалтай нийтийн орон байрны хэрэгцээ шаардлагыг хангах өөрийн нийгмийн зорилтыг тус холбооны үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлснээр уг холбооноос шууд бус, санхүүгийн бус өгөөж хүртэж болох юм. Гэвч зорилттой нийцэх нь бусад байгууллагыг тус байгууллага хянадаг гэж дүгнэхэд дангаараа хангалтгүй юм (36-р параграфыг үзнэ үү). Орон сууцны холбооны хувьд бүрэн эрхтэй байхын тулд тус орон нутгийн засаг захиргаа нь нутгийн засаг захиргааны зорилтуудыг хэрэгжүүлэхэд

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

өөртэйгээ хамтран ажиллуулах үүднээс уг орон сууцны холбоог удирдан чиглүүлэх чадвар боломжтой байх шаардлагатай.

### **Жишээ 11**

Хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн жилийн хурлыг хийдэг бөгөөд үүгээр холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх шийдвэрийг гаргадаг. Хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурал нь найман сарын дараа болно. Гэвч саналын эрхийн наад зах нь 5 хувийг дангаараа эсвэл хамтран эзэмшдэг хувьцаа эзэмшигч нар нь холбогдох үйл ажиллагааны талаархи одоогийн бодлогыг өөрчлөхийн тулд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болох боловч бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх шаардлага нь ийм хурлыг хамгийн наад зах нь 30 хоногийн дотор хуралдуулж болохгүй гэдгийг илэрхийлнэ. Холбогдох үйл ажиллагааны талаархи бодлогыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус буюу ээлжит хурлаар зөвхөн өөрчилж болох юм. Материаллаг дүнтэй хөрөнгийн борлуулалт, түүнчлэн томоохон хөрөнгө оруулалтыг хийх буюу данснаас хасах зөвшөөрөл нь ийм бодлогод хамаарна.

Дээрх нөхцөл байдлыг доор дурдсан 11А-11Г жишээнд ашиглана. Жишээ бүрийг тусад нь авч үзнэ.

### **Жишээ 11А**

Байгууллага нь бусад байгууллага дахь саналын эрхийн олонхийг эзэмшдэг. Тухайн байгууллага нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэхтэй холбоотой шийдвэрийг гаргах шаардлагатай болсон үед ийм шийдвэрийг гаргах чадвар боломжтой учраас түүний саналын эрх нь бодит байна. Өөрийн саналын эрхийг тухайн байгууллага хэрэгжүүлэхээс өмнө 30 хоног шаардлагатай байдаг нь уг байгууллага хувьцааны өмчлөлийг олж эзэмшсэн мөчөөс эхлэн тэдгээр холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх түүний одоогийн чадвар боломжид саад учруулахгүй юм.

### **Жишээ 11Б**

Тухайн байгууллага нь бусад байгууллагын хувьцааны олонхийн хувийг олж эзэмших форвард гэрээний оролцогч тал юм. Уг форвард гэрээний барагдуулах хугацаа нь 25 хоногийн дараа болно. Форвард гэрээг барагдуулснаас хойш наад зах нь 30 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж чадахгүй учраас одоогийн хувьцаа эзэмшигчид нь холбогдох үйл ажиллагааны талаархи одоогийн бодлогыг өөрчлөх боломжгүй юм. Иймээс уг байгууллага нь дээрх 11А жишээн дэх олонхийн хувийн эзэмшигчтэй үндсэндээ ижил эрхтэй байна (өөрөөр хэлбэл, форвард гэрээг эзэмшиж буй байгууллага нь шаардлагатай үед тухайн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх талаархи шийдвэрийг гаргаж чадна). Тухайн байгууллагын форвард гэрээ нь тэрхүү форвард гэрээг барагдуулахын өмнө ч гэсэн

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг уг байгууллагад олгодог бодит эрх юм.
<b>Жишээ 11В</b>  Тухайн байгууллага нь бусад байгууллагын хувьцааны олонхийн хувийг олж эзэмших бодит опционтой бөгөөд уг опцион нь 25 хоногийн дараа хэрэгжих боломжтой ба их мөнгөн ашигтай. Дээрх 11В жишээтэй ижил дүгнэлтэнд хүрнэ.
<b>Жишээ 11Г</b>  Байгууллага нь бусад байгууллагын хувьцааны олонхийн хувийг олж эзэмших форвард гэрээнд оролцогч тал бөгөөд уг бусад байгууллагын хувьд өөр бусад холбогдох эрхгүй. Энэхүү форвард гэрээний барагдуулах хугацаа нь 6 сарын дараа болно. Дээрх жишээнүүдээс ялгаатай нь, тухайн байгууллага нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжгүй байна. Одоогийн хувьцаа эзэмшигчид нь уг форвард гэрээг барагдуулахаас өмнө тухайн холбогдох үйл ажиллагааны талаар одоо баримталж буй бодлогыг өөрчилж чадах учраас холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжтой байна.

*Олонхийн саналын эрхгүй бүрэн эрх ба өмчлөлийн хувь оролцоонд хамаарах тусгай саналын эрх (МЗУ36-МЗУ37-р параграф)*

ҮЖ6. Бусад байгууллага дахь өмчлөлийн хувь оролцоонд хамаарах тусгай саналын эрх нь энэ Стандартын зорилгын хувьд бүрэн эрх үүсгэх эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

<b>Жишээ 12</b>  Төв засгийн газар нь нэгэн компанийг хувьчилсан ба өөрийн үндэсний эрх ашгийг хамгаалахын тулд “алтан хувьцаа” гэсэн механизмыг ашигласан. “Алтан хувьцаа” нь ямар нэг үнэ цэнэгүй буюу тухайн компанийн капиталын хувьд ямар нэг хувь хэмжээгээр эрх олгодоггүй. Тухайн компанийн хяналт буюу түүний 24 хувийн оролцоог уг төв засгийн газрын зөвшөөрөлгүйгээр худалдан борлуулж болохгүй гэж алтан хувьцаанд заасан.  Төв засгийн газар нь бодит эрхгүй боловч хамгаалалтын эрхтэй байна.
<b>Жишээ 13</b>  Төв засгийн газар нь тус компанийн бүх хувьцаагаа худалдан борлуулсан боловч алтан хувьцааг (нэг мөнгөн нэгжийн нэрлэсэн үнэ бүхий) хадгалж үлдсэн. Энэхүү алтан хувьцаа нь тус компанийн хувьцааны 15 хувийг эзэмших ингэснээр уг бизнесийн аливаа боломжит худалдан авалтыг хязгаарлах чадвар боломжийг Төрийн нарийн бичгийн даргад (хувьцаа



эзэмшигчийн хувьд) олгодог. Мөн энэ нь удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирлыг тухайн улсын иргэн байхыг шаарддаг. Энэхүү алтан хувьцааны гол зорилго нь үндэсний үндэсний аюулгүй байдлын үүднээс уг компанийг гадаадын эзэмшилд авахаас хамгаалах явдал юм.

Төв засгийн газар нь бодит эрхгүй боловч хамгаалалтын эрхтэй байна.

#### **Жишээ 14**

Төв засгийн газар нь батлан хамгаалах үйлчилгээний компаниудын ямар нэг хувьцааг эзэмшдэггүй. Гэвч батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын системийн зорилгоор стратегийн үйл ажиллагаа эрхлэн явуулах компаниудын талаар тусгайлан заасан хууль гаргасан бөгөөд батлан хамгаалах буюу аюулгүй байдлын суурь ашиг сонирхолд материаллаг нөлөө үзүүлж болох тохиолдолд засгийн газар нь дараах арга хэмжээ авч болох юм:

- (а) Худалдан авалтын болон мэдээллийн аюулгүй байдал, технологийн шилжүүлэлт, экспортын хяналттай холбоотойгоор ийм аливаа компани дахь хувь оролцооны хэн нэг этгээдийн худалдан авалтын хувьд тусгай нөхцөл тогтоох;
- (б) Батлан хамгаалах буюу үндэсний аюулгүй байдалд хор хөнөөл учруулж болох хэмжээг харгалзсанаар ийм аливаа компанийн саналын эрхтэй хувьцаат капитал дахь хувь оролцоог төрөөс бусад аливаа этгээдийн (шууд буюу шууд бусаар, дангаараа буюу хамтран) худалдан авалтанд хориг тавих; ба
- (в) Ийм аливаа компанийн хувьцаа эзэмшигчид буюу удирдах зөвлөл нь зарим онцгой шинжтэй ажил гүйлгээтэй холбоотой шийдвэр гаргалтанд хориг тавих (төрийн хяналтанд буй зарим компаниудын нэгдэл, тусгаарлалт, хөрөнгийн данснаас хасалт, татан буулгалт, корпорацийн зорилго буюу өмчийн эзэмшлийн дээд хязгаарын талаархи дүрмийн нэмэлт өөрчлөлт гэх мэт).

Ийм компаниудын хувьд засгийн газар нь бодит эрхгүй боловч хамгаалалтын эрхтэй байна.

*Удирдах зөвлөл буюу бусад удирдах байгууллагын хяналт (МЗУЗ8-р параграф)*

- ҮЖ7. Байгууллага нь бусад байгууллагын удирдах зөвлөл буюу бусад удирдах байгууллагыг энэ Стандартын зорилгын хувьд хянадаг эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан. Ийм хяналтын оршин байдал нь тухайн байгууллага бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй болох хангалттай эрхтэй эсэх талаархи нотолгоогоор хангаж болох юм.

#### **Жишээ 15**

Музейн санхүүжилтийг хариуцсан засгийн газрын хэлтэс газраас сонгосон итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн зөвлөл нь үндэсний музейг

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

удирдан явуулдаг. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь тус музейн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах эрхтэй байдаг.

Засгийн газрын хэлтэс газар нь тус музейн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн олонхийг томилох бүрэн эрхтэй. Уг хэлтэс газар нь тус музейн хувьд бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжтой юм.

### *Эдийн засгийн хараат байдал (МЗУ41-МЗУ42-р параграф)*

ҮЖ8. Бусад байгууллагын санхүүжилтээс хараат байдал нь энэ Стандартын хүрэн дэх бүрэн эрхийг үүсгэх эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

#### **Жишээ 16**

Тус судалгааны хүрээлэн нь төв засгийн газраас өөрийн ихэнх санхүүжилтийг авдаг олон байгууллагуудын нэг юм. Байгууллагууд нь саналаа танилцуулах ба сонгон шалгаруулалтын процессоор санхүүжилтийг хуваарилдаг. Уг судалгааны хүрээлэн нь санхүүжилтийг хүлээн авах эсвэл түүнээс татгалзах эрхтэй байдаг.

Тус судалгааны хүрээлэн нь засгийн газрын санхүүжилтээс татгалзах, санхүүжилтийн өөр хувилбар эх үүсвэрийг авах эсвэл үйл ажиллагаагаа зогсоох сонголтыг хийж болох учраас уг төв засгийн газар нь тэрхүү судалгааны хүрээлэнг хянадаггүй.

#### **Жишээ 17**

Нийтийн хоолны байгууллага нь төрийн өмчийн сургуульд хоол нийлүүлэх талаархи заавал биелүүлэх хэлцэл хийсэн. Энэхүү хэлцлийг тухайн байгууллага ба сургуулийн хооронд байгуулсан. Тус сургуулийн гэрээ нь уг нийтийн хоолны байгууллагын орлогын гол хэсгийг бүрдүүлдэг. Энэ төрлийн бүх хэлцэлд мөрдөгдөх зохицуулалтыг, үүн дотроо хоол тэжээлийн стандарт, худалдан авалтын бодлогыг заасан ерөнхий шаардлагууд байдаг. Жишээлбэл; хичнээн хэмжээний бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлээс худалдан авах ёстой гэдгийг тусгайлан заасан зохицуулалт байдаг.

Энэхүү хэлцэл нь таван жилийн хугацаатай. Таван жилийн эцэст уг нийтийн хоолны байгууллага нь сургуульд хоол үргэлжлүүлэн нийлүүлэхийг хүсвэл сонгон шалгаруулалтын ажиллагаанд оролцож, энэхүү бизнесийн төлөө бусад байгууллагуудтай өрсөлдөх шаардлагатай юм.

Тус нийтийн хоолны байгууллага нь сургуульд хоол нийлүүлэхээ зогсоох, өөр ажил хийх эсвэл үйл ажиллагаагаа зогсоох сонголттой учраас тус сургууль нь энэхүү нийтийн хоолны байгууллагыг хянадаггүй.

**Жишээ 18**

Олон улсын хандивлагч нь хөгжиж буй улс орны төслийг санхүүжүүлдэг. Тухайн хандивлагч нь төслийг хэрэгжүүлэхийн тулд тус улсын жижиг, орон нутгийн агентлагийг сонгодог. Уг орон нутгийн агентлаг нь өөрийн удирдах зөвлөлтэй боловч санхүүжилтийн хувьд тухайн хандивлагчаас ихээхэн хараат байдаг. Тус агентлаг нь хандивлагчаас авах санхүүжилтийг зогсоох бүрэн эрхтэй юм.

Тухайн агентлаг нь хандивлагчаас санхүүжилт авахаас татгалзах, өөр эх үүсвэрээс санхүүжилт авах эсвэл үйл ажиллагаагаа зогсоох сонголт хийж болох учраас уг олон улсын хандивлагч нь тус орон нутгийн агентлагийг хянадаггүй.

*Саналын эрх (МЗУ43-МЗУ48-р параграф)*

ҮЖ9. Бусад байгууллагад олонхи бус саналын эрхтэй байгууллага нь холбогдох үйл ажиллагааг дангаараа удирдан чиглүүлэх практик чадвар боломжтой эсэх, түүний эрх нь энэ Стандартын зорилгын хувьд уг бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй болоход хангалттай эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

**Жишээ 19**

Тухайн байгууллага нь бусад байгууллагын саналын эрхийн 48 хувийг олж эзэмшинэ. Үлдэх саналын эрхүүдийг хэдэн мянган хувьцаа эзэмшигчид эзэмшдэг бөгөөд тэдгээрийн тус тусын эзэмшилт нь саналын эрхийн 1 хувиас илүүгүй байдаг. Аль ч хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчидтэй зөвлөлдөх буюу хамтын шийдвэр гаргах ямар нэг тохиролцоо хийгээгүй. Бусад хувьцааны эзэмшилтийн харьцангуй тоо хэмжээнд үндэслэн уг олж эзэмших саналын эрхийн хувь хэмжээг үнэлэх үедээ, 48 хувийн хувь оролцоо нь түүнд хяналтын эрх олгоход хангалттай байна гэж тухайн байгууллага тодорхойлсон. Энэ тохиолдолд, өөрийн эзэмшлийн үнэмлэхүй хэмжээ болон бусад хувьцааны эзэмшилтийн харьцангуй хэмжээнд үндэслэн уг байгууллага нь бүрэн эрхийн шалгуурыг хангах хангалттай давамгайлсан саналын эрх түүнд байгаа бөгөөд бүрэн эрхийн аливаа бусад нотолгоог харгалзан үзэх шаардлагагүй гэж дүгнэсэн.

**Жишээ 20**

А байгууллага нь бусад байгууллагын саналын эрхийн 40 хувийг эзэмшдэг бөгөөд өөр 12 хөрөнгө оруулагч нь уг бусад байгууллагын саналын эрхийн 5 хувийг тус бүр эзэмшдэг. Холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэг бүхий удирдлагыг томилох, цуцлах ба тэдний урамшууллыг тогтоох эрхийг хувьцаа эзэмшигчдийн гэрээгээр А байгууллагад олгосон. Уг гэрээг өөрчлөхийн тулд хувьцаа эзэмшигчдийн гуравны хоёроос дээшхи дийлэнх олонхийн саналыг авах шаардлагатай. Энэ тохиолдолд, А байгууллагын хувьцааны эзэмшилтийн үнэмлэхүй

хэмжээ ба бусад хувьцааны эзэмшилтийн харьцангуй хэмжээ нь тухайн байгууллагад бүрэн эрх олгох хангалттай эрх түүнд байгаа эсэхийг тодорхойлоход дангаараа дүгнэлтийн шинжтэй болохгүй гэж уг А байгууллага дүгнэсэн. Гэвч удирдлагыг томилох, цуцлах ба тэдний урамшууллыг тогтоох түүний гэрээний эрх нь бусад байгууллагын хувьд тэрээр бүрэн эрхтэй гэж дүгнэхэд хангалттай гэж уг А байгууллага тодорхойлсон. А байгууллага нь бүрэн эрхтэй эсэхийг үнэлэх үедээ А байгууллага энэхүү эрхээ хэрэгжүүлэхгүй байж болох бодит байдал эсвэл удирдлагыг сонгох, томилох, цуцлах өөрийн эрхийг А байгууллага хэрэгжүүлэх магадлалыг харгалзан үзэхгүй.

**Жишээ 21**

А байгууллага нь бусад байгууллагын саналын эрхийн 45 хувийг эзэмшдэг. Өөр хоёр хөрөнгө оруулагч нь уг бусад байгууллагын саналын эрхийн 26 хувийг тус бүр эзэмшдэг. Үлдсэн саналын эрхийг гурван өөр хөрөнгө оруулагч тус бүр 1 хувиар эзэмшдэг. Шийдвэр гаргалтанд нөлөө үзүүлэх өөр бусад тохиролцоо байхгүй. Энэ тохиолдолд А байгууллагын саналын эрхийн хэмжээ болон бусад хувьцааны эзэмшилттэй түүний харьцуулсан хэмжээ нь А байгууллага бүрэн эрхгүй гэж дүгнэхэд хангалттай байна. Уг бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг А байгууллага удирдан чиглүүлэхэд саад учруулахын тулд ердөө өөр хоёр хөрөнгө оруулагч саналаа нэгтгэх шаардлагатай байна.

**Жишээ 22**

Тухайн байгууллага нь бусад байгууллагын саналын эрхийн 35 хувийг эзэмшдэг. Өөр гурван хувьцаа эзэмшигч нь уг бусад байгууллагын саналын эрхийн 5 хувийг тус бүр эзэмшдэг. Үлдэх саналын эрхийг маш олон тооны, өөр хувьцаа эзэмшигчид эзэмшдэг бөгөөд тэдгээрийн тус тусын эзэмшилт нь саналын эрхийн 1 хувиас илүүгүй байдаг. Аль ч хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчидтэй зөвлөлдөх буюу хамтын шийдвэр гаргах ямар нэг тохиролцоо хийгээгүй. Бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахын тулд тухайн хувьцаа эзэмшигчдийн хурлаар бүрдсэн саналын эрхийн олонхи зөвшөөрсөн байх шаардлагатай байдаг – хувьцаа эзэмшигчдийн хамгийн сүүлд болсон хуралд уг бусад байгууллагын саналын эрхийн 75 хувь нь оролцож, ирц бүрдсэн байна. Энэ тохиолдолд бусад хангалттай тооны хувьцаа эзэмшигчид нь тухайн байгууллагатай ижил санал өгснөөр тэрээр холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлж байсан эсэхээс үл хамааран тэрхүү хамгийн сүүлд болсон хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон бусад хөрөнгө оруулагчдын идэвхитэй оролцоо нь тухайн байгууллага тэдгээр холбогдох үйл ажиллагааг дангаараа удирдан чиглүүлэх практик чадвар боломжгүй гэдгийг илэрхийлж байна.

*Боломжит саналын эрх (МЗУ49-МЗУ52-р параграф)*

ҮЖ10. Боломжит саналын эрх нь энэ Стандартын зорилгын хувьд бодитой эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

**Жишээ 23**

А байгууллага нь бусад байгууллагын саналын эрхийн 70 хувийг эзэмшдэг. Б байгууллага нь уг бусад байгууллагын саналын эрхийн 30 хувь, түүнчлэн А байгууллагын саналын эрхийн тэн хагасыг олж эзэмших опционыг эзэмшдэг. Уг опцион нь дараагийн хоёр жилийн хугацаанд их мөнгөн алдагдалтай (ба хоёр жилийн хугацаанд ийм байхаар хүлээгдэж буй) тогтмол үнээр хэрэгжих боломжтой. А байгууллага нь өөрийн саналын эрхийг хэрэгжүүлсээр байгаа бөгөөд уг бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг идэвхитэй удирдан чиглүүлж байна. Ийм тохиолдолд А байгууллага нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжтой байгаа учраас тэрээр бүрэн эрхийн шалгуурыг хангах магадлалтай юм. Хэдийгээр Б байгууллага нь нэмэлт саналын эрх худалдан авахын тулд хэрэгжих боломжтой опционтой байгаа (хэрэв опционыг хэрэгжүүлвэл, энэ нь уг бусад байгууллагын саналын эрхийн олонхийг түүнд олгоно) боловч тэрхүү опционтой холбоотой нөхцөл, болзол нь уг опционыг бодит гэж үзэхээргүй тийм нөхцөлтэй байна.

**Жишээ 24**

А байгууллага болон өөр хоёр хөрөнгө оруулагчид нь уг бусад байгууллагын саналын эрхийн гуравны нэгийг тус бүр эзэмшдэг. Уг бусад байгууллагын бизнесийн үйл ажиллагаа нь А байгууллагатай нягт холбоотой байдаг. Өөрийн өмчийн хэрэглүүрээс гадна А байгууллага нь мөнгөн алдагдалтай (гэвч их мөнгөн алдагдалтай биш) байх тогтмол үнээр уг бусад байгууллагын энгийн хувьцаанд хүссэн үедээ хөрвүүлж болох өрийн хэрэглүүрийг бас эзэмшдэг. Хэрэв өрийн хэрэглүүрийг хөрвүүлвэл А байгууллага нь уг бусад байгууллагын саналын эрхийн 60 хувийг эзэмших юм. Хэрэв уг өрийн хэрэглүүрийг энгийн хувьцаанд хөрвүүлвэл А байгууллага нь өргөжилтийн хэмнэлтээс өгөөж хүртэнэ. А байгууллага нь холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг түүнд олгохоор бодитой байгаа, боломжит саналын эрхийн хамтаар уг бусад байгууллагын саналын эрхийг эзэмшдэг учраас тэрээр бусад байгууллагын хувьд бүрэн эрхтэй байна.

*Саналын буюу түүнтэй адилтгах эрхүүд нь өгөөжид мэдээдэхүйц нөлөөгүй байх үеийн бүрэн эрх (МЗУ53-МЗУ56-р параграф)*

ҮЖ11. Саналын буюу адилтгах эрхгүй тохиолдолд тухайн байгууллага нь энэ Стандартын зорилгын хувьд бүрэн эрхтэй эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

**Жишээ 25**

Төв засгийн газар нь соёлын болон өвийн зөвлөлүүдийг байгуулах асуудлыг зохицуулдаг хууль тогтоомжтой. Тэдгээр зөвлөлүүд нь эрх зүйн тусдаа статустай бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай байдаг. Зөвлөлүүдийн бүрэн эрх ба зорилгыг тэдгээрийн тайлагналын шаардлагын хамтаар хуулиар тогтоодог. Зөвлөл бүрийн үндсэн чиг үүрэг нь нийт өгөөж хүртэгчдийн нийтлэг ашиг тусын төлөө тухайн зөвлөлийн хөрөнгийг, ялангуяа үл хөдлөх хөрөнгийг захиран зарцуулах явдал юм. Зөвлөлүүд нь өгөөж хүртэгчдийн эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн сургалт, нийгмийн болон эдийн засгийн аж байдлыг урамшуулан дэмжихэд мөнгө зарцуулахыг зөвшөөрдөг. Зөвлөлүүд нь хууль тогтоомжид тусгайлан заагаагүй бол мөнгө зарцуулах хязгаарлагдмал эрх мэдэлтэй байдаг. Зөвлөл бүр нь жилийн санхүүгийн тайлан илтгэлээ Засгийн газарт хүргүүлэх ёстой. Өгөөж хүртэгчид (зөвлөл бүрийн тодорхойлсон ба тусгайлан заасан бүс нутгийн хүмүүсээс бүрдсэн) нь зөвлөлийн гишүүдийг сонгодог. Өгөөж хүртэгчид нь жилийн ээлжит хурлаараа санал өгөх замаар итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг гурван жилийн хугацаагаар томилдог. Зөвлөл бүр нь өөрийн үйл ажиллагааны болон санхүүгийн бодлого, стратегийг тодорхойлдог. Зөвлөлүүдийн зорилгод хүрэхэд хамгийн их нөлөө үзүүлдэг үйл ажиллагаа нь үл хөдлөх хөрөнгийн менежмент ба өгөөж хүртэгчдэд олгох мөнгө сангийн хуваарилалт юм.

Төв засгийн газар нь тэдгээр зөвлөлүүдийг хянадаггүй. Засгийн газар нь зөвлөлүүдийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомжийг гаргахад оролцдог боловч тэдгээр зөвлөлүүдийн холбогдох үйл ажиллагааны хувьд эрхгүй байдаг.

**Жишээ 26**

Таван орон нутгийн эрх бүхий байгууллагууд нь оролцогч эрх бүхий байгууллагуудад хамтын үйлчилгээ үзүүлэх тусдаа компанийг үүсгэн байгуулсан. Тус компани нь эдгээр орон нутгийн эрх бүхий байгууллагуудтай гэрээний үндсэн дээр ажилладаг. Компанийн гол зорилго нь эдгээр орон нутгийн эрх бүхий байгууллагуудад үйлчилгээ үзүүлэх явдал юм.

Бүх оролцогч орон нутгийн эрх бүхий байгууллагууд нь уг компанийг өмчлөх бөгөөд тус бүр нэг хувьцаа өмчилж, нэг саналын эрхтэй байдаг. Орон нутгийн засаг захиргаа нэг бүрийн гүйцэтгэх удирдлага нь уг компанийн удирдах зөвлөлийн гишүүн байхыг зөвшөөрдөг. Тус компанийн удирдах зөвлөл нь стратегийн чиглэл, бизнесийн ажил хэргийн зөвшөөрөл, гүйцэтгэлийн хяналт үнэлгээг хариуцдаг.

Хамтын үйл ажиллагаа бүрийн хувьд зөвлөлдөх бүлэг байдаг бөгөөд энэ нь үйл ажиллагааны удирдлага ба тухайн үйл ажиллагаатай холбоотой

шийдвэр гаргалтыг хариуцдаг. Зөвлөлдөх бүлэг бүр нь орон нутгийн засаг захиргаа тус бүрийн нэг нэг төлөөлөгчөөс бүрддэг.

Хамтын үйлчилгээний хэлцлийн өгөөж нь дараах байдалтай байна:

- Үйлчилгээний сайжруулсан түвшин ба чанар;
- Үйлчилгээ үзүүлэх харилцан уялдаатай ба тууштай хандлага;
- Дэмжлэг үзүүлэх болон захиргааны үйлчилгээний өртөг зардлын бууралт;
- Шинэ санаачлагыг хөгжүүлэх боломж; ба
- Худалдан авах ажиллагаанд олон зөвлөлийг нэг байгууллага төлөөлөн ажилласнаар үүсэх өргөжилтийн хэмнэлт.

Хэрэв цаашдын капиталын хэрэгцээг хангахын тулд хамтын үйлчилгээ үзүүлэх ажиллагааг бүрдүүлэн тогтоовол тус компани нь шинэ ангийн өмчийн хэрэглүүр гаргана эсвэл уг шинэ хөрөнгө дэх хувь оролцоог эзэмших тийм хяналтанд буй байгууллагыг үүсгэн байгуулна.

Компани нь өөрийн өртөг зардлыг хоёр арга замаар нөхдөг. Тус компани нь бөөн дүнгээр хийх худалдан авалтын ажиллагаанаас хэмнэсэн хувь хэсгийг өөртөө хадгалан үлдэх ба тэдгээр орон нутгийн эрх бүхий байгууллагуудад үзүүлсэн үйлчилгээний хувьд захиргааны болон ажил гүйлгээний зардлыг шингээж төлүүлнэ.

Орон нутгийн эрх бүхий байгууллагуудын аль нь ч тус компанийг дангаараа хянадаггүй. Тус компани дахь өөрийн хувь оролцоог хэрхэн тайлагнахыг шийдэх үедээ орон нутгийн эрх бүхий байгууллага бүр нь УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-т тодорхойлсон хамтын хэлэлцээрийн оролцогч нэг тал мөн эсэхээ бас харгалзан үзэх шаардлагатай.

### **Жишээ 27**

Орон нутгийн засаг захиргааны нэрийн өмнөөс спортын болон чөлөөт цаг өнгөрүүлэх байгууламжуудыг ажиллуулж, удирдан явуулах амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх төвийг халамжийн байгууллага байдлаар үүсгэн байгуулсан бөгөөд ийм баталгаагаар хангасан. Орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээний нөхцлийн дагуу тус амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх төв нь тухайн хотын спортын болон чөлөөт цаг өнгөрүүлэх байгууламжуудын үйл ажиллагааны удирдлага, үйлчилгээний нийлүүлэлт ба хөгжүүлэлтийг хариуцах юм. Тус төв нь тухайн орон нутгийн засаг захиргааны одоогийн амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх байгууламжийг ажиллуулах шаардлагатай. Шаардлагатай үйлчилгээний түвшин, үүн дотроо ажиллах цаг, орон тоо зэргийг тухайн орон нутгийн засаг захиргаа тогтоодог. Амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх төвийн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн засаг захиргааны урт хугацааны

төлөвлөгөөтэй нийцсэн байх ёстой бөгөөд тус төвийн үйл ажиллагааны гол хэсгийг тэрхүү орон нутгийн засаг захиргаанаас санхүүжүүлдэг. Амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх төв нь тухайн орон нутгийн засаг захиргааны зөвшөөрөлгүйгээр шинэ байгууламжийг үүсгэн бий болгож болохгүй, мөн аливаа бусад үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй.

Уг амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх төв нь үйл ажиллагаа явуулахаа боливол түүний олсон мөнгийг ижил төсөөтэй зорилго бүхий өөр халамжийн байгууллагад хуваарилан шилжүүлэх ёстой. Орон нутгийн засаг захиргаа нь уг амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх төвийн өр төлбөрийг хариуцахгүй (түүний хариуцлага нь нэг тооцооны нэгжээр хязгаарлагдана).

Орон нутгийн засаг захиргаа нь тус амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх төвийг хянадаг. Уг амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх төвийн үйл ажиллагааг хэрхэн явуулах талаар нарийвчлан зааснаар тухайн орон нутгийн засаг захиргаа нь тус амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх төвийн үйл ажиллагаа болон үйл ажиллагаанаас өөрт бий болох өгөөжийн шинж төрлийг урьдчилан тодорхойлдог.

#### **Жишээ 28**

Орон нутгийн засаг захиргаа нь амралтын төвүүд, номын сангууд, театруудыг халамжийн байгууллагад шилжүүлсэн.

Уг байгууллагыг бий болгосноор тухайн орон нутгийн засаг захиргаа нь өртөг зардлын хэмнэлт, тэдгээр байгууламжийг олон нийт ашиглах ашиглалтын нэмэгдэлт, татварын илүү таатай хандлага, халамжийн байгууллагаар хязгаарлагдах санхүүжилтийг олж авах илүү сайн боломжийн үр дүнд өгөөж хүртэнэ гэж үзэж байна. Тус байгууллага нь ханган бүрдүүлэх байгууламжийн шинж төрөл, хэмжээг тогтоон шийдвэрлэх ба аливаа бусад халамжийн зорилгоор үйл ажиллагаа явуулж болох юм. Уг байгууллагын удирдах зөвлөлийг олон нийт сонгодог. Орон нутгийн засаг захиргаа нь тус байгууллагын удирдах зөвлөлд нэг төлөөлөгч оруулах эрхтэй байдаг. Энэхүү байгууллага нь аливаа ашгийг авч үлдэх ба өөрийн зорилгын дагуу ашиглах шаардлагатай юм.

Орон нутгийн засаг захиргаа нь тус байгууллагын үйл ажиллагаанаас өгөөж хүртдэг боловч уг байгууллагыг хянадаггүй. Орон нутгийн засаг захиргаа нь тус байгууллага нөөцөө хэрхэн ашиглахыг удирдан чиглүүлж чадахгүй.

#### **Жишээ 29**

А байгууллага нь А хотыг тохижуулах хөтөлбөр, арга хэмжээ, санаачлагыг урамшуулж, дэмжих ба хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь төрөл бүрийн үйлчилгээ, үүн дотроо сараачсан зургийн хуулж арилгалт, гоёж тохижуулах төсөл, байгаль орчны арга хэмжээний зохион



## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

байгуулалтанд зориулан тухайн орон нутгийн засаг захиргаанаас санхүүжилт авдаг. Уг байгууллага нь эдгээр үйлчилгээний нийлүүлэлтийн талаархи өөрийн гүйцэтгэлийг тухай орон нутгийн засаг захиргаанд буцаан тайлагнадаг. Хэрэв ийм байгууллага байгаагүй бол тухайн орон нутгийн засаг захиргаа нь ийм үйлчилгээг үзүүлэх өөр бусад арга замыг эрж хайх шаардлагатай байсан. Тус байгууллага нь тухайн орон нутгийн нийгэмлэгээс, үүн дотроо орон нутгийн бизнесийн байгууллага, сургууль, олон нийтийн бүлгүүд болон хувь хүмүүсээс хандив, сайн дурын ажил хэлбэрээр мөн туслалцаа авдаг.

Тухайн орон нутгийн засаг захиргааны сонгогдсон албан тушаалтан нь уг байгууллагыг анх үүсгэн байгуулсан.

Тухайн орон нутгийн засаг захиргааны удирдах зөвлөл нь уг байгууллагын бүх итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг (хүйсийн тэнцвэртэй байдал, итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн байршил гэх мэт тодорхой шаардлагуудыг харгалзан үзсэнээр) томилдог. Уг байгууллага нь 5-12 итгэмжлэгдсэн төлөөлөгчидтэй байдаг. Эдгээр итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь албан хаагчдыг томилдог.

Тус байгууллагын дүрмийн өөрчлөлтийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид болон тухайн орон нутгийн эрх бүхий байгууллага зөвшөөрөн батлах ёстой.

Хэрэв тус байгууллагыг татан буулгавал түүний илүүдэл хөрөнгийг тухайн газар зүйн бүс дэх ижил төсөөтэй халамжийн байгууллагад шилжүүлэх ёстой. Хөрөнгийг ингэж шилжүүлэхдээ тухайн орон нутгийн засаг захиргааны зөвшөөрлийг авах шаардлагатай.

Орон нутгийн засаг захиргаа нь уг байгууллагын хувьд янз бүрийн эрхтэй бөгөөд үүнд дараах эрхүүд хамаарна:

- (а) Холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвар боломж бүхий тус байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилох, өөрчлөх буюу чөлөөлөх;
- (б) Уг байгууллагын холбогдох үйл ажиллагаанд хамаарах үйл ажиллагааны болон капитал хөрөнгийн төсвийг батлах буюу хориг тавих; ба
- (в) Байгууллагын томоохон хөрөнгө буюу тухайн байгууллагыг бүхэлд нь худалдан борлуулах гэх мэт тэрхүү байгууллагын гол өөрчлөлтүүдэд хориг тавих.

Орон нутгийн засаг захиргаа нь өөрийн хэлцлээр дамжуулан тус байгууллагын холбогдох үйл ажиллагаа (үйлчилгээ)-г удирдан чиглүүлэх чадвар боломжтой, иймээс тухайн үзүүлж буй үйлчилгээний өртөг зардал ба чанарт нөлөө үзүүлэх боломжтой байдаг. Тухайн орон нутгийн засаг захиргаа нь хувьсах өгөөжийн (үйлчилгээний эдийн засгийн үр нөлөө ба үйлчилгээний чанарын аль алины) хувьд эрсдэл хүлээдэг. Орон

нутгийн засаг захиргаа нь эдгээр өгөөжид нөлөөлөхийн тулд өөрийн бүрэн эрхийг ашигладаг тул уг байгууллагыг хянадаг.

**Жишээ 30**

А байгууллага нь шинэ байшингийн барилгын ажил, хуучин байшингийн засвар шинэчлэл, орон байрны болон амьжиргааны нөхцлийн сайжруулалтанд дэмжлэг үзүүлэх улсын секторын байгууллага юм. Мөн тус байгууллага нь орон байрны санхүүжилт авахад дэмжлэг үзүүлж, орон сууцны санхүүжилт олголтын хувьд өрсөлдөөн болон үр ашгийг нэмэгдүүлдэг.

А байгууллага нь нарийн тодорхойлсон зорилго бүхий итгэмжлэгдсэн байгууллагыг тусад нь үүсгэн байгуулсан. Уг итгэмжлэгдсэн байгууллагын чиг үүрэг нь шалгуур хангах орон байрны зээлд хувь оролцоо эзэмших ба моргейжийн бонд гаргах явдал юм. А байгууллага нь тэрхүү итгэмжлэгдсэн байгууллагын гаргасан бондод баталгаа гаргадаг боловч байнгын санхүүжилтээр хангадаггүй. Тус итгэмжлэгдсэн байгууллага нь хөрөнгө оруулалтаас олсон орлогоороо өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлдэг. Хэрэв итгэмжлэгдсэн байгууллагыг татан буулгавал түүний хөрөнгийг нэг буюу хэд хэдэн халамжийн байгууллагад хуваарилах юм. А байгууллага нь тус итгэмжлэгдсэн байгууллагын үйл ажиллагааны хувьд шийдвэр гаргах байнгын эрхгүй байдаг.

А байгууллага нь итгэмжлэгдсэн байгууллагыг үүсгэн байгуулах үедээ түүний холбогдох үйл ажиллагааг тодорхойлсон тул уг итгэмжлэгдсэн байгууллагын холбогдох үйл ажиллагааны хувьд бүрэн эрхтэй байна. Тус итгэмжлэгдсэн байгууллагыг үүсгэн байгуулах үедээ А байгууллагын тодорхойлсон уг итгэмжлэгдсэн байгууллагын үйл ажиллагаа нь А байгууллага өөрийн зорилгыг биелүүлэхэд туслалцаа үзүүлдэг учраас, мөн түүнчлэн баталгаа гаргасан бондын эрсдлийн улмаас А байгууллага нь хувьсах өгөөжийн хувьд бас эрсдэл хүлээдэг.

**Жишээ 31**

Санхүүжилтийн агентлагийг хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулсан. Арван орон нутгийн эрх бүхий байгууллагууд болон төв засгийн газар нь уг агентлагийг хамтран өмчилдөг. Тус агентлаг нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг. Уг санхүүжилтийн агентлаг нь өрийн санхүүжилт босгож, тэдгээр оролцогч орон нутгийн эрх бүхий байгууллагуудад олгодог. Түүний үндсэн зорилго нь орон нутгийн эрх бүхий байгууллагуудыг өртөг зардлын хувьд илүү хэмнэлттэй бөгөөд олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэрээр хангах явдал юм. Тус агентлаг нь тухайн бизнестэй ул үндэслэлтэйгээр хамааралтай буюу түүнийг дагалдах эсвэл түүнтэй холбоотой гэж удирдах зөвлөлийн үзсэн аливаа бусад үйл ажиллагааг эрхлэн явуулж болох юм.

Оролцогч орон нутгийн эрх бүхий байгууллагуудын хувьд үүсэх гол өгөөж нь зээлийн өртгийн бууралт юм. Тус санхүүжилтийн агентлагийн удирдах

зөвлөл нь ногдол ашиг олгохоор шийдвэрлэж болох боловч ногдол ашгийн төлбөр нь бага дүнтэй байхаар хүлээгдэж байна.

Удирдах зөвлөл нь уг санхүүжилтийн агентлагийн үйл ажиллагааны стратегийн чиглэл ба хяналтыг хариуцдаг. Удирдах зөвлөл нь 4-7 захиралтай байх бөгөөд энэ нь хараат бус захирлуудын олонхи байдаг.

Мөн хувьцаа эзэмшигчдээс томилсон арван хүнээс (үүн дотроо, төв засгийн газраас томилсон нэг хүнээс) бүрдэх хувьцаа эзэмшигчдийн зөвлөлтэй байдаг. Хувьцаа эзэмшигчдийн зөвлөл нь дараах үүрэгтэй байдаг:

- Санхүүжилтийн агентлагийн болон удирдах зөвлөлийн ажлын гүйцэтгэлийг шалгаж, хувьцаа эзэмшигчдэд тайлагнах;
- Захирлуудын томилгоо, чөлөөлөлт, сольж өөрчлөлт, цалин урамшууллын талаар хувьцаа эзэмшигчдэд зөвлөмж өгөх; ба
- Хувьцаа эзэмшигчдийн засаглах шийдвэрийг уялдан зохицуулах.

Уг санхүүжилтийн агентлаг нь удирдах зөвлөл ба/буюу хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрөн баталсан өөрийн зээлийн болон хөрөнгө оруулалтын бодлогын дагуу өрийн үнэт цаасыг худалдаж авдаг.

Уг санхүүжилтийн агентлагт үндсэн хувьцаа эзэмшилтийн бүрэн эрх байдлаар оролцохын тулд орон нутгийн засаг захиргаа бүр нь 100,000 ТН-ийн анхны капитал хөрөнгө оруулалтыг хийсэн бөгөөд үл хөдлөх хөрөнгийн ирээдүйн татварын хамгаалалт бүрдүүлж, өөрийн зээлийн хэрэгцээ шаардлагын тодорхой хэсгийг гурван жилийн хугацаанд тухайн санхүүжилтийн агентлагаас зээлдэн авахыг зөвшөөрсөн.

Төв засгийн газар болон оролцогч орон нутгийн эрх бүхий байгууллагуудын аль нь ч уг санхүүжилтийн агентлагийг хянадаггүй. Тус санхүүжилтийн агентлаг дахь өөрсдийн хувь оролцоог хэрхэн тайлагнахыг шийдвэрлэхдээ, төв засгийн газар болон оролцогч орон нутгийн эрх бүхий байгууллагууд нь УСНББОУС 37-д тодорхойлсончлон, уг хамтын хэлэлцээрийн оролцогч тал болох эсэхээ мөн харгалзан үзэх шаардлагатай юм.

### **Жишээ 32**

Үүсгэн байгуулах баримт бичигт тусгайлан заасанчлан, А байгууллагын ганц бизнесийн үйл ажиллагаа нь Б байгууллагын авлагуудыг худалдан авч, түүнд өдөр тутмын үйлчилгээ үзүүлэх явдал юм. Өдөр тутмын үйлчилгээ нь төлөгдөх хугацаа болсон үндсэн дүнгийн болон хүүний төлбөрүүдийг цуглуулж, шилжүүлэх үйл ажиллагаа юм. Авлага төлөгдөхгүй, үл биелүүлэх тохиолдолд А байгууллага ба Б байгууллагын хоорондох буцаах гэрээгээр тусдаа тохиролцсоны дагуу А байгууллага нь уг авлагыг Б байгууллагад шууд буцаан өгдөг. Үл биелүүлэх авлагыг удирдан зохицуулах нь А байгууллагын санхүүгийн үр дүнд мэдэгдэхүйц

нөлөө үзүүлж болох цорын ганц үйл ажиллагаа учраас энэ нь холбогдох үйл ажиллагаа болно. Үл биелүүлэлтээс өмнөх авлагын удирдан зохицуулалт нь А байгууллагын санхүүгийн үр дүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болох бодит шийдвэр гаргахыг шаарддаггүй учраас энэ нь холбогдох үйл ажиллагаа биш юм. Үл биелүүлэлтийн өмнөх үйл ажиллагааг урьдчилан тодорхойлж болох бөгөөд түүний дүн нь зөвхөн төлөгдөх хугацаа болсон мөнгөн гүйлгээний цуглуулалт ба түүнийг Б байгууллагад дамжуулан шилжүүлэлт байдаг. Иймээс А байгууллагын санхүүгийн үр дүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх уг А байгууллагын ерөнхий үйл ажиллагааг үнэлэх үедээ тэрхүү үл биелэгдэх хөрөнгийг удирдан зохицуулах талаархи Б байгууллагын эрхийг зөвхөн харгалзан үзнэ. Энэ жишээнд, А байгууллагын бүтэц нь шийдвэр гаргах шаардлагатай болсон зөвхөн тэр үед, санхүүгийн үр дүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үйл ажиллагааны талаархи шийдвэрийг гаргах эрх Б байгууллагад байна гэдгийг илэрхийлж байна. Буцаах гэрээний нөхцлүүд нь А байгууллагын ерөнхий ажил гүйлгээ ба түүний үүсгэн байгуулалтын салшгүй нэг хэсэг юм. Иймээс хэдийгээр Б байгууллага нь зөвхөн үл биелэгдэх авлагын өмчлөлийг хүлээн авдаг бөгөөд уг үл биелүүлсэн авлагыг А байгууллагын хууль ёсны хил хязгаараас гадуур удирдан зохицуулдаг боловч А байгууллагын үүсгэн байгуулах баримт бичгийг тэрхүү буцаах гэрээний нөхцлийн хамтаар авч үзсэнээр Б байгууллага нь А байгууллагын хувьд бүрэн эрхтэй гэсэн дүгнэлтэнд хүрнэ.

*Бусад байгууллагын хувьсах өгөөжийн хувьд хүлээх эрсдэл эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрх (МЗУ57-р параграф)*

ҮЖ12. Байгууллага нь бусад байгууллагаас хувьсах үр өгөөж хүртдэг эсэхийг энэ Стандартын зорилгоор хэрхэн үнэлэхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

### **Жишээ 33**

Бага насны хүүхдийн эрт боловсролын чанартай үйлчилгээ бүхий гэр бүлд ээлтэй бодлогыг их, дээд сургуулиудад хэрэгжүүлэх нь оюутнууд болон ажиллагчдыг татах ба тэднийг хадгалан үлдэхэд чухал ач холбогдолтой гэдгийг судалгаа харуулсан. Энэ нь өндөр түвшний ажилтнууд болон мастер, докторын зэргийн оюутнуудыг татах, эргээд тухайн их, дээд сургуулийн нэр хүндийг өндөрт өргөх ба судалгааны санхүүжилт олж авах түүний чадвар боломжид туслалцаа үзүүлэхэд ихээхэн чухал ач холбогдолтой юм.

Дээрх үндсэн мэдээлэл нь доор дурдсан 33А ба 33Б жишээнүүдэд хамаарна. Жишээ бүрийг тусад нь авч үзнэ.

### **Жишээ 33А**

А их сургууль нь хүүхэд асрах долоон төвийг байгуулсан (А их сургууль нь өөрийн боловсролын хөтөлбөрүүдэд зориулан засгийн газрын

санхүүжилт авдаг боловч хүүхэд асрах төвүүдийг засгийн газар биш, харин тухайн их сургууль өөрөө байгуулсан). Тус төвүүд нь уг их сургуулийн эзэмшлийн барилгад үйл ажиллагаагаа явуулдаг. Төв бүр нь өөрийн менежер, ажилтан ба төсөвтэй байдаг. Эдгээр төвүүдийг зөвхөн их сургуулийн ажилтан болон оюутнууд ашиглах боломжтой. Тус их сургууль нь хүүхэд асрах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага юм. Тухайн их сургууль нь тэдгээр төвүүдийг хаах эсвэл өөр байршилд шилжүүлэх эрхтэй байдаг. Хүүхэд асрах төв нь уг их сургуулийн үл хөдлөх хөрөнгөнд байрлаж байгаа тул ажилтнууд болон эцэг эхчүүд нь тус их сургуулийн эрүүл мэндийн болон аюулгүй байдлын бодлогыг дагаж мөрдөх шаардлагатай юм. Хүүхэд асрах төвийн удирдлагын баг нь бусад бүх үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох чадвар боломжтой байдаг.

А их сургууль нь өөрийн сургуулийн бүсэд хүүхэд асрах үйлчилгээ үзүүлснээр санхүүгийн бус өгөөж хүртдэг. Хэдийгээр А их сургууль нь эдгээр төвүүдийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй боловч уг төвүүдийг хаах эсвэл ажлын цагийг өөрчлөх чадвар боломжтой байдаг.

А их сургууль нь эдгээр хүүхэд асрах төвүүдийг хянадаг.

### **Жишээ 33Б**

Б их сургууль нь тус их сургуулийн бүсэд хүүхэд асрах үйлчилгээ үзүүлэхэд зориулан үнэ төлбөргүй барилга байгууламжаар хангадаг. Зохих ёсоор байгуулагдсан нийгэмлэг нь хүүхэд асрах үйлчилгээг үзүүлдэг. Хүүхэд асрах төвөөр үйлчлүүлж буй бүх эцэг эх нь тус нийгэмлэгийн гишүүд юм. Гишүүд нь тус нийгэмлэгийн удирдах зөвлөлийг томилдог бөгөөд хүүхэд асрах төвийн үйл ажиллагааны болон санхүүгийн бодлогыг хариуцдаг. Ажилтнууд, оюутнууд, олон нийт болон нэн тэргүүнд оюутнууд нь тус хүүхэд асрах төвөөр үйлчлүүлдэг. Хүүхэд асрах төв нь уг их сургуулийн үл хөдлөх хөрөнгөнд байрлаж байгаа тул ажилтнууд болон эцэг эхчүүд нь тус их сургуулийн эрүүл мэндийн болон аюулгүй байдлын бодлогыг дагаж мөрдөх шаардлагатай юм. Тус нийгэмлэг нь хүүхэд асрах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага юм. Хэрэв уг нийгэмлэг нь үйл ажиллагаа явуулахаа боливол түүний хөрөнгө нөөцийг ижил төсөвтэй ашгийн бус байгууллагад хуваарилах ёстой. Тус нийгэмлэг нь өөрийн үйл ажиллагааг явуулахдаа тухайн их сургуулийн барилгыг ашиглахгүй байх сонголт хийж болох юм.

Тухайн их сургууль нь өөрийн сургуулийн бүсэд хүүхэд асрах үйлчилгээ үзүүлснээр санхүүгийн бус өгөөж хүртдэг боловч уг нийгэмлэгийн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхгүй байдаг. Хүүхдүүдийн эцэг эхчүүд болох тус нийгэмлэгийн гишүүд нь уг нийгэмлэгийн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхтэй юм. Тухайн их сургууль нь уг нийгэмлэгийг хянадаггүй.

## Бүрэн эрх ба өгөөжийн хоорондох холбоо

*Төлөөлсөн бүрэн эрх (МЗУ60-МЗУ63-р параграф)*

ҮЖ13. Байгууллага нь энэ Стандартын зорилгын хувьд үндсэн оролцогчийн эсвэл төлөөлөн оролцогчийн үүрэг гүйцэтгэж буй эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

### **Жишээ 34**

Засгийн газрын хэлтэс нь улсын секторын бусад байгууллагын гүйцэтгэлийг хянан үнэлэх үүрэгтэй байж болох юм. Тус хяналт үнэлгээний хэлтсийн үүрэг бол засгийн газрын зорилготой уг бусад байгууллагын арга хандлага нийцэж буй эсэхийг шалган магадлах, ажлын гүйцэтгэл ба үр дүнгийн талаархи чанарын баталгааг Сайдуудад гаргаж өгөх, аливаа эрсдлийг үнэлж, Сайдад мэдэгдэх явдал юм. Уг хэлтэс нь Сайдтай шууд гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээнд түүний хяналт үнэлгээний үүргийг заасан байдаг. Тус хэлтэс нь бусад байгууллагаас мэдээлэл авах бүрэн эрхтэй бөгөөд тухайн байгууллагын санхүүжилтийн аливаа хүсэлтийн талаар Сайдад зөвлөгөө өгдөг. Мөн тодорхой үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг уг бусад байгууллагад олгох эсэх талаар тус хэлтэс нь Сайдад зөвлөдөг. Тухайн хэлтэс нь Сайдын өмнөөс төлөөлөн оролцогчийн үүрэг гүйцэтгэж байна.

### **Жишээ 35**

Мужийн засгийн газар нь тухайн бүс нутагт эрүүл мэндийн хөтөлбөр болон бусад эрүүл мэндийн санаачлагуудыг үр өгөөжтэй хэрэгжүүлэхийн тулд хөрөнгө босгох ажилд хамтран ажиллах итгэмжлэгдсэн байгууллагыг үүсгэн байгуулсан. Мөн уг итгэмжлэгдсэн байгууллага нь зориулагдсан хандивын мөнгө сангаар хөрөнгө оруулалт хийж, удирдан зохицуулна. Уг босгосон мөнгө санг тухайн бүс нутаг дахь төрийн өмчийн эмнэлгүүд болон өндөр настаны асрамжийн газруудад зарцуулна.

Тус мужийн засгийн газар нь уг итгэмжлэгдсэн байгууллагын удирдах зөвлөлийн бүх төлөөлөгчдийг томилох ба тухайн итгэмжлэгдсэн байгууллагын үйл ажиллагааны зардлыг хариуцан санхүүжүүлнэ. Уг итгэмжлэгдсэн байгууллага нь зохих ёсоор бүртгэгдсэн халамжийн байгууллага бөгөөд орлогын албан татвараас чөлөөлөгддөг.

Дараах шинжилгээнд үндэслэн харгалзан үзвэл, тус мужийн засгийн газар нь уг итгэмжлэгдсэн байгууллагыг хянаж байна:

(а) Мужийн засгийн газар нь итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд удирдамж чиглэл өгч чадах бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь уг итгэмжлэгдсэн байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвар боломжтой байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь тухайн итгэмжлэгдсэн байгууллагын хувьд бүрэн эрхтэй бөгөөд мужийн засгийн газар нь итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг өөрийн

саналаар сольж өөрчилж чадна. Тухайн байгууллагын эрх ашгийн төлөө ажиллах төлөөлөгчдийн итгэмжлэгдсэн үүрэг нь тэрхүү байгууллагын хувьд уг мужийн засгийн газар бүрэн эрхтэй байхад саад учруулахгүй;

- (б) Мужийн засгийн газар нь тухайн итгэмжлэгдсэн байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй байдаг;
- (в) Мужийн засгийн газар нь итгэмжлэгдсэн байгууллагын өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн байгууллагын хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглаж чадна; ба
- (г) Итгэмжлэгдсэн байгууллагын үйл ажиллагаа нь тус мужийн засгийн газрын үйл ажиллагааны нэмэлт гүйцээлт болдог.

### **Жишээ 36**

Нийгэмд үйлчилгээ үзүүлэхийн тулд хууль хэрэгжүүлэгч байгууллагыг хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулсан. Энэхүү хууль хэрэгжүүлэгч байгууллага нь түүний үйл ажиллагаанд хяналт тавьж, өдөр тутмын үйл ажиллагааг хариуцах удирдах зөвлөлтэй байдаг. Мужийн засгийн газрын өмнөөс Эрүүл мэндийн Сайд нь уг хууль хэрэгжүүлэгч байгууллагын удирдах зөвлөлийг томилдог ба тэрхүү хууль хэрэгжүүлэгч байгууллагын удирдах зөвлөл нь Сайдаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр тухайн байгууллагын гүйцэтгэх захирлыг томилдог.

Мужийн засгийн газрын Эрүүл мэндийн газар нь уг мужийн иргэдийн эрүүл мэндийн системийн хувьд “системийн менежер”-ийн үүрэг гүйцэтгэдэг. Уг үүрэгт дараах зүйлс хамаарна:

- (а) Мужийн хэмжээний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлөвлөгөө боловсруулах гэх мэт стратегийн манлайлал;
- (б) Үйлчилгээний гэрээ байгуулах, капитал ажлын зөвшөөрөл олгох, мужийн хэмжээний салбарын харилцааг удирдан зохицуулах, үүн дотроо уг хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудын ажил эрхлэлтийн хугацаа, нөхцлийг тогтоох гэх мэт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд зориулсан удирдамж чиглэл; ба
- (в) Эрх бүхий байгууллагын гүйцэтгэлийн (жишээлбэл; эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, санхүүгийн мэдээ) хяналт үнэлгээ, түүнчлэн гүйцэтгэл нь тогтоосон гүйцэтгэлийн шалгуурыг хангахгүй байх тохиолдол засварлах арга хэмжээ авч хэрэгжүүлэлт.

Дараах гол шийдвэрүүдийн хувьд Сайдын зөвшөөрлийг тусгайлан авах шаардлагатай байдаг:

- (а) Хууль хэрэгжүүлэгч байгууллагатай үйлчилгээний гэрээ байгуулах;
- (б) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний заавал биелүүлэх удирдамж чиглэлийг гаргах;

(в) Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлөвлөгөө болон капиталын ажлын төлөвлөлтийг эцэслэн батлах; ба

(г) Уг хууль хэрэгжүүлэгч байгууллагын гүйцэтгэх удирдлагын ажилтнуудын ажил эрхлэлт ба цалин урамшууллыг тогтоох.

Тус эрүүл мэндийн газар нь өөрийн бүх үйл ажиллагааны болон капиталын зарлагын санхүүжилтийг уг мужийн засгийн газраас авдаг.

Дээр дурдсан баримт материал ба нөхцөл байдлыг харгалзан үзвэл тус Эрүүл мэндийн газар нь уг хууль хэрэгжүүлэгч байгууллагын хувьд Сайдын өмнөөс төлөөлөн оролцогчийн үүргийг ерөнхийдөө гүйцэтгэдэг. Энэ нь Эрүүл мэндийн газрын шийдвэр гаргах хязгаарлагдмал бүрэн эрхээс тодорхой харагдаж байна. Тус эрүүл мэндийн газар нь уг хууль хэрэгжүүлэгч байгууллагыг хянадаггүй.

Сайд нь уг хууль хэрэгжүүлэгч байгууллагын удирдах зөвлөлийг томилж, байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх гол шийдвэрүүдийг зөвшөөрөн баталдаг тул түүний холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхтэй байна. Хяналтын бусад шалгуур (хувьсах өгөөж, бүрэн эрх ба өгөөжийн хоорондох холбоо) төлөвлөсний дагуу хангагддаг гэж үзвэл Сайд нь уг хууль хэрэгжүүлэгч байгууллагыг хянадаг байх юм. Иймээс уг хууль хэрэгжүүлэгч байгууллагыг тухайн мужийн нийт засгийн газрын түвшний нийтлэг зорилготой санхүүгийн тайланд нэгтгэнэ.

### **Жишээ 37**

Энэхүү жишээнд доор дурдсанаас бусад тохиолдолд Жишээ 36-гийн өгөгдлийг ашигласан:

(а) Сайд нь уг хууль хэрэгжүүлэгч байгууллагын удирдах зөвлөлийн гишүүдийг томилох бүрэн эрхийг Эрүүл мэндийн газрын даргад төлөөлүүлэн шилжүүлсэн;

(б) Хууль хэрэгжүүлэгч байгууллагын гүйцэтгэх захирлыг түүний удирдах зөвлөл томилоход Сайдын зөвшөөрлийг авах шаардлагагүй байдаг;

(в) Сайд нь гол шийдвэрүүдийг зөвшөөрөн батлах бүрэн эрхийг Эрүүл мэндийн газрын даргад төлөөлүүлэн шилжүүлсэн; ба

(г) Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн үнэлгээ нь уг хууль хэрэгжүүлэгч байгууллагын гүйцэтгэлийг агуулсан байдаг.

Сайд нь Эрүүл мэндийн газрын даргад төлөөлүүлэн шилжүүлсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжтой байгаа боловч практикт үүнийг хэрэгжүүлэх магадлал багатай юм.

Энэ жишээнд Эрүүл мэндийн газрын даргад Сайдын төлөөлүүлэн шилжүүлсэн эрхийн үр дүнд тус Эрүүл мэндийн газрын шийдвэр гаргах бүрэн эрхийн цар хүрээ нь мэдэгдэхүйц нэмэгдсэн. Эрүүл мэндийн газар нь уг төлөөллийн дагуу үндсэн оролцогчийн үүрэг гүйцэтгэж байгаа тул



тус Эрүүл мэндийн газар нь өөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зорилгыг биелүүлэхдээ тэрхүү хууль хэрэгжүүлэгч байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар боломжтой байна. Мөн Эрүүл мэндийн газар нь өөрийн өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөөлөх бүрэн эрхийн хувьд эрх мэдлээ ашиглах чадвар боломжтой тул тус Эрүүл мэндийн газар нь уг хууль хэрэгжүүлэгч байгууллагыг хянадаг.

**Жишээ 38**

Засгийн газрын санхүү, татварын асуудал эрхэлсэн газрын (Төрийн сангийн)-ын даргыг хэд хэдэн хөрөнгө оруулалтын санг удирдах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хуулийн дагуу томилдог. Эдгээр хөрөнгө оруулалтын санг тусгайлан заасан татвараар санхүүжүүлдэг бөгөөд Холбооны улсын халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд түүний мөнгө санг ашигладаг. Төрийн сан нь эдгээр сангуудад хамаарах уг тусгайлан заасан ихэнх татварын орлогыг хурааж бүрдүүлдэг. Бусад агентлагууд нь мөн орлогын зарим хэсгийг хураан бүрдүүлж, Төрийн санд шилжүүлдэг.

Эдгээр санг захиран зарцуулах үүрэг хариуцлагыг Төрийн санд даалгасан. Сан тус бүрийн хувьд Төрийн сан нь тухайн санд орсон бүх орлогоор нэн даруй хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд холбогдох агентлагт мөнгө шаардлагатай болох хүртэл тэрхүү итгэмжлэн хариуцуулсан сангийн хөрөнгийг хадгалдаг.

Холбогдох агентлагууд нь мөнгө шаардлагатай гэдгийг тодорхойлсон үед Төрийн сан нь эдгээр сангуудын хөрөнгө оруулалтын үлдэгдлээс үнэт цаасыг эргэлтээс гаргаж, мөнгөн орлогыг, үүн дотроо тухайн хөрөнгө оруулалтаас олсон хүүг тэрхүү агентлагийн зарцуулах хөтөлбөрийн дансанд шилжүүлдэг. Төрийн сан нь агентлаг болгонд сар бүр болон бусад үечилсэн хугацаагаар тайлан гаргаж өгдөг. Төрийн сан нь өөрийн үзүүлсэн үйлчилгээний хувьд менежментийн төлбөрийг нэхэмжилж авдаг.

Төрийн сан нь эдгээр сангуудыг хянадаггүй.

**Жишээ 39**

Орон нутгийн засаг захиргаа нь тус бүрдээ өөр өөр дүүрэгт тусгайлан хамаарах арван санг захиран зарцуулдаг. Өмнө нь өөрсдийн орон нутгийн засаг захиргаатай байсан боловч бусад дүүргүүдтэй нэгтгэсэн дүүргүүдэд харъяалагдах болсон тодорхой хөрөнгүүд (газар, үл хөдлөх хөрөнгө, хөрөнгө оруулалт гэх мэт)-ийг эдгээр сангууд эзэмшдэг. Эдгээр сангууд нь тухайн дүүргийн хөрөнгүүдтэй холбоотой орлого түүнчлэн, үл хөдлөх хөрөнгийн татвар гэх мэт зарим татварыг хүлээн авдаг. Эдгээр зарим хөрөнгүүдийг эзэмших ба тусгайлан заасан орлогыг хүлээн авах тус сангуудын эрхийг хууль тогтоомжид заасан байдаг. Тухайн сангийн

хөрөнгө болон орлогыг зөвхөн хуучин дүүргүүдийн оршин суугчдын ач тусын төлөө ашиглан зарцуулж болох юм.

Орон нутгийн засаг захиргаа нь тэдгээр сангуудын зарцуулалтын хувьд өргөн эрх мэдэлтэй байдаг. Орон нутгийн засаг захиргааны зөв зүйтэй гэж үзсэн ул үндэслэлтэй шүүн тунгаалтыг ашиглах ба хуучин дүүргийн оршин суугчдын ашиг сонирхлыг харгалзсан тийм арга маягаар иргэдийн сайн сайхны төлөө уг санг ашиглан зарцуулах ёстой. Орон нутгийн засаг захиргаа нь зөвлөлийн татварын ногдуулалтанд хамаарахгүй зарлагын хувьд тухайн санг ашиглан зарцуулж болох юм. Тус сангаас гаргах зарлага нь хуулиар зөвшөөрөгдсөн зорилгын хувьд зарцуулагдах ёстой.

Тухайн орон нутгийн засаг захиргаа нь эдгээр сангуудыг хянадаг.

#### **Жишээ 40**

Үндэсний баялагийн сан (Сан) нь үндсэн хуулиар тогтоосон байнгын сан бөгөөд засгийн газрын корпораци түүнийг удирдан зохицуулдаг. Тус сан нь газрын тосны борлуулалтын орлогын наад зах нь 25 хувийг авах эрхтэй гэж хууль тогтоомжид заасан байдаг. Уг сан нь одоогийн болон ирээдүйн хойч үеийн иргэдийн сайн сайхны төлөө энэхүү орлогын тодорхой хэсгийг хадгална.

Корпораци нь тус сангийн болон тухайн улсын бусад тодорхой хөрөнгө оруулалтын аль алины хөрөнгийг удирдан зохицуулах бөгөөд үүнийхөө төлөө төлбөр авдаг. Тухайн корпораци нь уг сангийн орлогыг захиран зарцуулдаггүй байж болно. Сангийн орлогыг зарцуулах шийдвэрийг Улсын Их Хурлаас гаргадаг. Жил бүр тус сангийн орлогыг хууль тогтоомжид заасан тодорхой шалгуурыг хангаж буй оршин суугчдад олгох жилийн төлбөр ба үйл ажиллагааны зардалд зориулан төсөвлөн хуваарилдаг.

Уг корпораци нь үндэсний баялгийн санг хянадаггүй, харин зөвхөн төлөөлөн оролцогчийн үүрэг гүйцэтгэдэг.

#### **Жишээ 41**

Тухайн орон нутгийн хууль, тогтоомжоор шаардсанчлан, хөрөнгө оруулалтын эрхийн бичигт заасан, нарийн тодорхойлсон үзүүлэлтүүдийн дагуу шийдвэр гаргагч (сангийн менежер) нь олон нийтэд арилжаалдаг, зохицуулалт бүхий санг байгуулж, зах зээлд гаргах ба удирдан зохицуулдаг. Олон нийтэд арилжаалдаг байгууллагуудын өмчийн үнэт цаасны төрөлжсөн багц дахь хөрөнгө оруулалт байдлаар уг санг хөрөнгө оруулагчдад танилцуулан борлуулдаг. Тэрхүү тодорхойлсон үзүүлэлтүүдийн хүрээнд, сангийн менежер нь хөрөнгө оруулалт хийх тухайн хөрөнгийн хувьд бүрэн эрх мэдэлтэй байдаг. Сангийн менежер нь уг санд түүний 10 хувьтай хувь тэнцүүлэн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд өөрийн үзүүлсэн үйлчилгээний төлөө зах зээлийн түвшнээр тооцон тухайн сангийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийн 1 хувьтай тэнцүү

үйлчилгээний хөлс авдаг. Энэхүү үйлчилгээний хөлс нь түүний үзүүлсэн үйлчилгээнд тохирч байна. Сангийн менежер нь өөрийн 10 хувийн хөрөнгө оруулалтаас давсан сангийн алдагдлын хувьд ямар нэг хариуцлага хүлээхгүй. Сан нь хараат бус захирлуудын зөвлөл байгуулах албагүй бөгөөд ийм зөвлөл байгуулаагүй. Хөрөнгө оруулагч нар нь сангийн менежерийн шийдвэр гаргах эрхэд нөлөө үзүүлэх өөр ямар нэг бодит эрхийг эзэмшдэггүй боловч тухайн сангаас тогтоосон хязгаарт багтаан өөрийн хувь оролцоог буцаан татаж болох юм.

Хэдийгээр хөрөнгө оруулалтын эрхийн бичигт заасан үзүүлэлтүүдийн хүрээнд, зохицуулалтын шаардлагуудын дагуу үйл ажиллагаагаа явуулах боловч сангийн менежер нь тухайн сангийн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг түүнд олгох шийдвэр гаргах эрхтэй байдаг - хөрөнгө оруулагч нар нь сангийн менежерийн шийдвэр гаргах эрхэд нөлөө үзүүлж болох бодит эрхийг эзэмшдэггүй. Сангийн менежер нь өөрийн үзүүлсэн үйлчилгээнд тохирох үйлчилгээний хөлсийг зах зээлийн түвшнээр тооцон авдаг бөгөөд мөн тухайн санд хувь тэнцүүлэн хөрөнгө оруулалт хийсэн. Сангийн үйл ажиллагаанаас үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн улмаас шагнал урамшуулал ба түүний хөрөнгө оруулалтын хувьд сангийн менежерт эрсдэл үүсдэг боловч уг сангийн менежер нь үндсэн оролцогч гэдгийг илэрхийлэх тийм чухал ач холбогдолтой эрсдэл үүсдэггүй.

Энэ жишээнд, сангийн өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд уг сангийн менежерт учрах эрсдлийг түүний хязгаарласан үзүүлэлтүүдийн хүрээнд шийдвэр гаргах бүрэн эрхийн хамтаар авч үзвэл, тухайн сангийн менежер төлөөлөн оролцогч гэдэг нь харагдаж байна. Иймээс сангийн менежер нь уг санг хянадаггүй гэж дүгнэнэ.

#### **Жишээ 42**

Шийдвэр гаргагч нь олон тооны хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын боломж олгодог санг байгуулж, зах зээлд гаргасан ба түүнийг удирдан зохицуулдаг. Шийдвэр гаргагч (сангийн менежер) нь бүх хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлын төлөө бөгөөд тухайн санг удирдах гэрээний дагуу шийдвэр гаргах ёстой. Гэхдээ сангийн менежер нь шийдвэр гаргах өргөн эрх мэдэлтэй байдаг. Сангийн менежер нь өөрийн үзүүлсэн үйлчилгээний төлөө зах зээлийн түвшнээр тооцон тухайн удирдан зохицуулж буй хөрөнгийн 1 хувь, түүнчлэн ашгийн тогтоосон түвшинд хүрвэл уг сангийн цэвэр ашгийн 20 хувьтай тэнцүү үйлчилгээний хөлс авдаг. Энэхүү үйлчилгээний хөлс нь түүний үзүүлсэн үйлчилгээнд тохирч байна.

Хэдийгээр бүх хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргах ёстой боловч сангийн менежер нь сангийн холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх талаар шийдвэр гаргах өргөн их эрх мэдэлтэй байна. Сангийн менежерт түүний үзүүлсэн үйлчилгээнд тохирох тогтмол болон үр дүнд үндэслэсэн хөлс төлдөг. Түүнчлэн, шагнал урамшуулал нь сангийн үйл ажиллагаанаас бий болох өгөөжийн

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл учруулахгүйгээр сангийн үнэ цэнийг нэмэгдүүлэх бусад хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолтой уг сангийн менежерийн ашиг сонирхлыг нэгтгэдэг бөгөөд үүнийг тусад нь авч үзвэл, шагнал урамшуулал нь тухайн сангийн менежер үндсэн оролцогч гэдгийг илэрхийлэх тийм ач холбогдолтой байна.

Энэхүү бодит байдлын талаархи өгөгдлийг доорх 42А-42В жишээнд ашиглана. Жишээ бүр нь тусдаа тохиолдол гэж үзнэ.

### **Жишээ 42А**

Сангийн менежер нь уг санд мөн 2 хувийн хөрөнгө оруулалттай бөгөөд энэ нь бусад хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолтой уг сангийн менежерийн ашиг сонирхлыг нэгтгэдэг. Сангийн менежер нь өөрийн 2 хувийн хөрөнгө оруулалтаас давсан сангийн алдагдлын хувьд ямар нэг хариуцлага хүлээхгүй. Хөрөнгө оруулагч нар нь зөвхөн гэрээ зөрчсөн үед энгийн олонхийн саналаар сангийн менежерийг халж, өөрчилж болох юм.

Сангийн менежерийн 2 хувийн хөрөнгө оруулалт нь тухайн сангийн менежерийг үндсэн оролцогч гэдгийг илэрхийлэх тийм мэдэгдэхүйц эрсдэл үүсгэхгүй боловч сангийн үйл ажиллагаанаас бий болох өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд түүнд учрах эрсдлийг нэмэгдүүлнэ. Сангийн менежерийг халж солих бусад хөрөнгө оруулагчдын эрх нь зөвхөн гэрээ зөрчигдсөн үед хэрэгжих боломжтой учраас хамгаалалтын эрх гэж үзнэ. Энэ жишээнд, хэдийгээр сангийн менежер нь шийдвэр гаргах өргөн эрх мэдэлтэй бөгөөд өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд өөрийн хувь оролцоо болон шагнал урамшуулал хэлбэрээр эрсдэл хүлээдэг боловч уг сангийн менежерийн эрсдэл нь түүнийг төлөөлөн оролцогч гэдгийг илэрхийлж байна. Иймээс сангийн менежер нь уг санг хянадаггүй гэж дүгнэнэ.

### **Жишээ 42Б**

Сангийн менежер нь тухайн санд хувь тэнцүүлсэн мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгө оруулалттай боловч уг хөрөнгө оруулалтаас давсан сангийн алдагдлын хувьд ямар нэг хариуцлага хүлээхгүй. Хөрөнгө оруулагч нар нь зөвхөн гэрээ зөрчсөн үед энгийн олонхийн саналаар сангийн менежерийг халж, өөрчилж болох юм.

Энэ жишээнд, сангийн менежерийг халж солих бусад хөрөнгө оруулагчдын эрх нь зөвхөн гэрээ зөрчигдсөн үед хэрэгжих боломжтой учраас хамгаалалтын эрх гэж үзнэ. Сангийн менежер түүний үзүүлсэн үйлчилгээнд тохирох тогтмол болон үр дүнд үндэслэсэн хувьсах хөлс төлдөг боловч уг сангийн менежерийн хөрөнгө оруулалт ба шагнал урамшууллын нэгдсэн дүн нь тухайн сангийн үйл ажиллагаанаас үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэлд өртөх бөгөөд тэрхүү сангийн менежер нь үндсэн оролцогч гэдгийг илэрхийлэх тийм мэдэгдэхүйц дүнтэй байна. Сангийн менежерийн эдийн засгийн хувь

оролцоо (шагнал урамшуулал болон бусад хувь оролцоог нийтэд нь авч үзэхэд) болон холбогдох хувьсан өөрчлөлтийн ач холбогдол хичнээн их байх тусам сангийн менежер нь шинжилгээ хийхдээ тэдгээр эдийн засгийн хувь оролцоонд илүү их ач холбогдол өгөх бөгөөд уг сангийн менежер нь үндсэн оролцогч байх магадлал төдий чинээ их байна.

Жишээлбэл; өөрийн шагнал урамшуулал болон бусад хүчин зүйлсийг харгалзан үзсэнээр, сангийн менежер нь уг санг хянадаг болоход 20 хувийн хөрөнгө оруулалт хангалттай гэж дүгнэж болох юм. Гэхдээ үүнээс өөр нөхцөл байдалд (өөрөөр хэлбэл, шагнал урамшуулал буюу бусад хүчин зүйлс өөр байх) хөрөнгө оруулалтын түвшин нь дээрхээс өөр байхад хяналт үүсэж болох юм.

#### **Жишээ 42В**

Сангийн менежер нь уг санд хувь тэнцүүлсэн 20 хувийн хөрөнгө оруулалттай бөгөөд өөрийн 20 хувийн хөрөнгө оруулалтаас давсан сангийн алдагдлын хувьд ямар нэг хариуцлага хүлээхгүй. Сан нь захирлуудын зөвлөлтэй, түүний бүх гишүүд нь сангийн менежерээс хараат бус бөгөөд тэднийг өөр хөрөнгө оруулагч нар томилдог. Захирлуудын Зөвлөл нь сангийн менежерийг жил бүр томилдог. Хэрэв Зөвлөл нь сангийн менежерийн гэрээг дахин сунгахгүй гэж шийдвэрлэсэн бол уг сангийн менежерийн үзүүлдэг үйлчилгээг тухайн салбар чиглэлийн өөр бусад менежерүүд гүйцэтгэх боломжтой байдаг.

Сангийн менежерт түүний үзүүлсэн үйлчилгээнд тохирох тогтмол болон үр дүнд үндэслэсэн хувьсах хөлс төлдөг боловч уг сангийн менежерийн 20 хувийн хөрөнгө оруулалт ба шагнал урамшууллын нэгдсэн дүн нь тухайн сангийн үйл ажиллагаанаас үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг бөгөөд тэрхүү сангийн менежер нь үндсэн оролцогч гэдгийг илэрхийлэх тийм мэдэгдэхүйц дүнтэй байна. Гэвч хөрөнгө оруулагч нар нь сангийн менежерийг халж солих бодит эрхтэй – хэрэв хөрөнгө оруулагч нар нь сангийн менежерийг солихоор шийдвэрлэвэл ингэх боломжтой байх механизмыг захирлуудын зөвлөл бүрдүүлсэн.

Энэ жишээнд, сангийн менежер нь шинжилгээ хийхдээ түүнийг цуцлах бодит эрхэд илүү их ач холбогдол өгнө. Иймээс хэдийгээр сангийн менежер нь шийдвэр гаргах өргөн эрх мэдэлтэй бөгөөд сангийн өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд өөрийн шагнал урамшуулал ба хөрөнгө оруулалтаар эрсдэл хүлээдэг боловч бусад хөрөнгө оруулагч нарын эзэмшиж буй бодит эрх нь тухайн сангийн менежер төлөөлөн оролцогч гэдгийг илэрхийлж байна. Иймээс сангийн менежер нь уг санг хянадаггүй гэж дүгнэнэ.

#### **Жишээ 43**

Хөрөнгөөр баталгаажсан тогтмол хүүтэй үнэт цаасны багц худалдан авах зорилгоор А байгууллагыг үүсгэн байгуулсан бөгөөд тогтмол хүүтэй

өрийн хэрэглүүр болон өмчийн хэрэглүүрээр санхүүжүүлнэ. Өмчийн хэрэглүүр нь өрийн хөрөнгө оруулагч нарыг эхний алдагдлаас хамгаалах ба А байгууллагын аливаа үлдэх өгөөжийг авах зорилготой байдаг. Уг багц дахь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны гаргагчдын боломжит үл биелүүлэлттэй холбоотойгоор зээлийн эрсдэлд, түүнчлэн багцын менежменттэй холбоотойгоор хүүний түвшний эрсдэлд өртөх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгө оруулалт гэж энэхүү ажил гүйлгээг боломжит өрийн хөрөнгө оруулагч нарт танилцуулан гаргасан. Анх үүсгэн байгуулах үед өмчийн хэрэглүүр нь тухайн худалдан авсан хөрөнгийн үнэ цэнийн 10 хувийг илэрхийлж байсан. Шийдвэр гаргагч (хөрөнгийн менежер) нь А байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан үзүүлэлтүүдийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргаснаар хөрөнгийн идэвхитэй багцыг удирдан зохион байгуулдаг. Эдгээр үйлчилгээний төлөө хөрөнгийн менежер нь зах зээлийн түвшнээр тооцон тогтмол хөлс (өөрөөр хэлбэл, удирдан зохицуулж буй хөрөнгийн 1 хувь), түүнчлэн А байгууллагын ашгийн түвшин тохиролцсон түвшнээс давж илүү гарвал үр дүнд үндэслэсэн хувьсах хөлс (өөрөөр хэлбэл, ашгийн 10 хувь) авдаг. Энэхүү үйлчилгээний хөлс нь түүний үзүүлсэн үйлчилгээнд тохирсон байна. Уг хөрөнгийн менежер нь А байгууллагын өмчийн хэрэглүүрийн 35 хувийг эзэмшдэг. А байгууллагын өмчийн хэрэглүүрийн үлдсэн 65 хувь болон бүх өрийн хэрэглүүрийг маш олон тооны, ихээхэн тархсан, харилцан хамааралгүй гуравдагч талын хөрөнгө оруулагч нар эзэмшдэг. Бусад хөрөнгө оруулагчдын энгийн олонхийн шийдвэрээр уг хөрөнгийн менежерийг шалтгаан заахгүйгээр сольж өөрчлөх боломжтой байдаг.

Хөрөнгийн менежерт түүний үзүүлсэн үйлчилгээнд тохирсон тогтмол болон үр дүнд үндэслэсэн хувьсах хөлс төлдөг. Шагнал урамшуулал нь сангийн үнэ цэнийг нэмэгдүүлэх бусад хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолтой уг хөрөнгийн менежерийн ашиг сонирхлыг нэгтгэдэг. Тухайн хөрөнгийн менежер нь өмчийн хэрэглүүрийн 35 хувийг эзэмшдэг учраас сангийн үйл ажиллагаанаас болон өөрийн шагнал урамшууллаас бий болох өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг.

Хэдийгээр А байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан үзүүлэлтүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах боловч уг хөрөнгийн менежер нь А байгууллагын өгөөжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргах одоогийн чадвар, боломжтой байна – цуцлах эрхийг маш олон тооны, өргөн тархсан хөрөнгө оруулагч нар эзэмшдэг учраас тэдгээр бусад хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй цуцлах эрх нь шинжилгээнд маш бага ач холбогдолтой байна. Энэ жишээнд, хөрөнгийн менежер нь тухайн сангийн өгөөжийн хувьсан өөрчлөлтийн улмаас түүний цэвэр хөрөнгө/өмчийн хувь оролцоонд учрах эрсдэлд хамгийн их ач холбогдол өгөх юм. Түүний цэвэр хөрөнгө/өмчийн хувь оролцоо нь өрийн хэрэглүүрээс тэргүүн бус ээлжийн эрхтэй байдаг. Өмчийн хэрэглүүрийн 35 хувийн эзэмшилт нь А байгууллагын алдагдлаас хүлээх эрсдэл ба өгөөжөөс хүртэх эрхийн хувьд тэргүүн бус ээлжинд байгаа нь тухайн хөрөнгийн менежер үндсэн оролцогч гэдгийг илэрхийлэх тийм

мэдэгдэхүйц дүнтэй байна. Иймээс хөрөнгийн менежер нь А байгууллагыг хянадаг гэж дүгнэнэ.

**Жишээ 44**

Шийдвэр гаргагч (санхүүжүүлэгч) нь олон төрөлт үйл ажиллагааны зуучлагчийг санхүүжүүлдэг бөгөөд зуучлагч нь харилцан хамааралгүй гуравдагч талын хөрөнгө оруулагч нарт богино хугацаат өрийн хэрэглүүрийг гаргадаг. Өндөр хүүтэй, дунд хугацаатай бөгөөд тухайн багц дахь хөрөнгө гаргагчдын боломжит үл биелүүлэлттэй холбоотой зээлийн эрсдэл өртөлт хамгийн бага байх хөрөнгүүдийн багцад оруулах хөрөнгө оруулалт гэж уг ажил гүйлгээг боломжит хөрөнгө оруулагч нарт танилцуулан гаргасан. Янз бүрийн шилжүүлэгчид нь өндөр чанартай, дунд хугацаат хөрөнгийн багцуудыг уг зуучлагчид борлуулдаг. Шилжүүлэгч бүр нь уг зуучлагчид борлуулсан хөрөнгийн багцдаа үйлчилгээ үзүүлдэг бөгөөд зах зээлийн түвшнээр тооцсон үйлчилгээний хөлс авснаар тухайн үл биелүүлсэн авлагыг удирдан зохицуулдаг. Мөн шилжүүлэгч бүр нь уг зуучлагчид шилжүүлсэн хөрөнгөнд хэт их барьцаа гаргаж өгснөөр өөрийн хөрөнгийн багцаас үүсэх зээлийн алдагдлын хувьд эхний алдагдлын хамгаалалтыг бүрдүүлдэг. Санхүүжүүлэгч нь зуучлагчийн нөхцлийг тогтоодог бөгөөд зах зээлийн түвшнээр тооцсон үйлчилгээний хөлс авч, уг зуучлагчийн үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг. Энэхүү үйлчилгээний хөлс нь түүний үзүүлсэн үйлчилгээнд тохирсон байна. Санхүүжүүлэгч нь уг зуучлагчид хөрөнгөө борлуулах борлуулагч нарыг зөвшөөрөн баталдаг, зуучлагчийн худалдан авах хөрөнгөнд зөвшөөрөл олгодог бөгөөд зуучлагчийн санхүүжилтийн талаархи шийдвэрийг гаргадаг. Санхүүжүүлэгч нь бүх хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолын төлөө ажиллах ёстой.

Санхүүжүүлэгч нь зуучлагчийн аливаа үлдэх өгөөжийг хүртэх эрхтэй бөгөөд уг зуучлагчийг зээлийн сайжруулалтын болон төлбөрийн чадварын хэрэгслээр хангадаг. Санхүүжүүлэгчийн олгодог зээлийн сайжруулалт нь шилжүүлэгчдийн хариуцсан алдагдлын дараа, тухайн зуучлагчийн бүх хөрөнгийн 5 хүртэлх хувиар алдагдлыг хариуцдаг. Төлбөрийн чадварын хэрэгслийг үл биелүүлсэн хөрөнгийн хувьд ашигладаггүй. Хөрөнгө оруулагч нар нь тухайн санхүүжүүлэгчийн шийдвэр гаргах эрхэд нөлөө үзүүлж болох бодит эрхийг эзэмшдэггүй.

Санхүүжүүлэгчид түүний үзүүлсэн үйлчилгээнд тохирох үйлчилгээний хөлсийг зах зээлийн түвшнээр тооцон төлдөг боловч тухайн зуучлагчийн аливаа үлдэх өгөөжийг хүртэх түүний эрх, зээлийн сайжруулалтын болон төлбөрийн чадварын хэрэгслээр хангах (өөрөөр хэлбэл, зуучлагч нь дунд хугацаат хөрөнгүүдийг санхүүжүүлэхийн тулд богино хугацаат өрийн хэрэглүүр ашигласнаар төлбөрийн чадварын эрсдэлд өртдөг) нөхцлийн улмаас уг санхүүжүүлэгч нь зуучлагчийн үйл ажиллагаанаас үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг. Хэдийгээр шилжүүлэгч бүр нь уг зуучлагчийн хөрөнгийн үнэ цэнэд нөлөөлөх шийдвэр гаргах эрхтэй боловч санхүүжүүлэгч нь зуучлагчийн өгөөжид хамгийн ихээр нөлөө үзүүлэх [өөрөөр хэлбэл, санхүүжүүлэгч нь

зуучлагчийн нөхцлийг тогтоодог, зуучлагчийн хөрөнгө (худалдан авах хөрөнгө болон тэдгээр хөрөнгийн шилжүүлэгчдийг зөвшөөрөн батлах) ба санхүүжилтийн (шинэ хөрөнгө оруулалтыг байнга тогтмол олох шаардлагатай байдаг) талаархи шийдвэрийг гаргах эрхтэй байдаг] үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг түүнд олгох шийдвэр гаргах өргөн эрх мэдэлтэй байдаг. Зуучлагчийн аливаа үлдэх өгөөжийг хүртэх эрх, зээлийн сайжруулалтын болон төлбөрийн чадварын хэрэгслээр хангах нөхцөл нь уг зуучлагчийн үйл ажиллагаанаас бий болох өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд тухайн санхүүжүүлэгчид эрсдэл учруулдаг бөгөөд энэ нь бусад хөрөнгө оруулагчдын эрсдлээс өөр байдаг. Энэхүү эрсдэл нь тухайн санхүүжүүлэгч үндсэн оролцогч гэдгийг илэрхийлнэ, ингэснээр санхүүжүүлэгч нь уг зуучлагчийг хянадаг гэж дүгнэнэ. Бүх хөрөнгө оруулагчдын эрх ашгийн төлөө ажиллах уг санхүүжүүлэгчийн үүрэг нь түүнийг үндсэн оролцогч байхад саад учруулахгүй юм.

*Нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд: Хяналтаа алдах (52-55А параграф)*

ҮЖ13А Өөртөө үйл ажиллагаа агуулаагүй, хяналтанд буй байгууллага дахь хувь оролцооны борлуулалтын арга хандлагыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

#### **Жишээ 44А**

Хяналт тавигч байгууллага нь өөртөө үйл ажиллагаа агуулаагүй, хяналтанд буй байгууллага дахь хувь оролцоог 100 хувь эзэмшдэг. Тус хяналт тавигч байгууллага нь өөрөө 20 хувийн оролцоотой байдаг хараат байгууллагадаа уг хяналтанд буй байгууллага дахь өөрийн хувь оролцооны 70 хувийг борлуулсан. Энэ ажил гүйлгээний үр дүнд тус хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд буй байгууллага дахь хяналтаа алдсан. Хяналтанд буй байгууллагын цэвэр хөрөнгийн дансны үнэ нь 100ТН ба борлуулсан хувь оролцооны дансны үнэ нь 70ТН ( $70ТН = 100ТН \times 70\%$ ) байна. Борлуулалтаас хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнэ нь 210ТН ба энэ нь мөн уг борлуулсан хувь оролцооны бодит үнэ цэнэ юм. Өмнө нь хяналтанд байсан энэхүү байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалт нь өмчийн арга ашиглан тайлагнах хараат байгууллага болох бөгөөд түүний бодит үнэ цэнэ нь 90ТН байна. 55А параграфтаар шаардсан устгалтыг хийхийн өмнө 54-55-р параграфын дагуу тодорхойлсон олз нь 200ТН ( $200ТН = 210ТН + 90ТН - 100ТН$ ) байна. Энэхүү олз нь дараах хоёр хэсгээс бүрдэнэ:

- (а) Хяналтанд буй байгууллагын 70 хувийн хувь оролцоог хараат байгууллагад борлуулснаас үүссэн олз (140ТН). Энэ олз нь хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнэ (210ТН) ба борлуулсан хувь оролцооны дансны үнийн (70ТН) хоорондох зөрүү юм. 55А параграфын дагуу тус хяналт тавигч байгууллага нь уг одоо байгаа хараат байгууллага дахь харилцан холбоогүй хөрөнгө оруулагчдын хувь оролцоонд хамаарах олзын дүнг өөрийн ашиг, алдагдалд



хүлээн зөвшөөрнө. Энэ нь уг олзын 80 хувь буюу 112ТН ( $112ТН = 140ТН \times 80\%$ ) байна. Олзын үлдсэн 20 хувийг ( $28ТН = 140ТН \times 20\%$ ) одоо байгаа хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж, устгана.

- (б) Өмнө нь хяналтанд байсан байгууллагад шууд хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүссэн олз (60ТН). Энэ олз нь үүний өмнө хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ (90ТН) ба тэрхүү хяналтанд байсан байгууллагын цэвэр хөрөнгийн дансны үнэ ( $30ТН = 100ТН \times 30\%$ ) хоорондох зөрүү юм. Хяналт тавигч байгууллага нь уг шинэ хараат байгууллага дахь харилцан холбоогүй хөрөнгө оруулагчдын хувь оролцоонд хамаарах олзын дүнг 55А параграфын дагуу өөрийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Энэ нь уг олзын 56 хувь ( $70ТН \times 80\%$ ) буюу 34ТН ( $34ТН = 60ТН \times 56\%$ ) байна. Олзын үлдсэн 44 хувь буюу 26ТН ( $26ТН = 60ТН \times 44\%$ )-ийг уг өмнө нь хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж, устгана.

*Хөрөнгө оруулалтын байгууллагууд (МЗУ88-МЗУ106-р параграф)*

ҮЖ14. Байгууллага нь энэ Стандартын зорилгын хувьд хөрөнгө оруулалтын байгууллага эсэх үнэлгээг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

**Жишээ 45**

“Хязгаарлагдмал нөхөрлөл” гэсэн нэртэй байгууллагыг 20X1 онд 10 жилийн хугацаатайгаар, хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл хэлбэрээр үүсгэн байгуулсан. Хязгаарлагдмал нөхөрлөлийн зорилго нь хурдацтай өсөлтийн боломж бүхий байгууллагуудад хөрөнгө оруулалт хийх ба тэдгээр хөрөнгө оруулалтын хугацаанд капиталын үнийн өсөлтийн ашиг олох зорилготой гэж уг санал болгож буй баримт бичигт заасан. Тус нөхөрлөлийн БХГ (хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн бүрэн хариуцлагатай гишүүн) нь Хязгаарлагдмал нөхөрлөлийн капиталын 1 хувийг бүрдүүлдэг бөгөөд уг нөхөрлөлийн хувьд тохиромжтой хөрөнгө оруулалтыг тогтоох үүрэг хариуцлагатай байдаг. Нөхөрлөлийн БХГ-тэй холбоогүй, бүрэн бус хариуцлагатай ойролцоогоор 75 гишүүд нь тухайн нөхөрлөлийн капиталын 99 хувийг бүрдүүлдэг.

Хязгаарлагдмал нөхөрлөл нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа 20X1 онд эхэлсэн. Гэвч 20X1 оны эцэс гэхэд тохиромжтой хөрөнгө оруулалтыг олж тогтоогоогүй байсан. 20X2 онд Хязгаарлагдмал нөхөрлөл нь АБВ корпорацийн хяналтын хувь оролцоог олж эзэмшсэн. Хязгаарлагдмал нөхөрлөл нь 20X3 он хүртэл хөрөнгө оруулалтын өөр ажил гүйлгээг хийх боломжгүй байсан бөгөөд харин 20X3 онд үйл ажиллагаа эрхэлж буй нэмэлт таван компанийн өмчийн хувь оролцоог олж эзэмшсэн. Хязгаарлагдмал нөхөрлөл нь эдгээр өмчийн хувь оролцоог олж эзэмшихээс өөр бусад үйл ажиллагаа явуулаагүй.

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хязгаарлагдмал нөхөрлөл нь хөрөнгө оруулалтаа бодит үнэ цэнийн сууриар үнэлж, хэмждэг бөгөөд энэхүү мэдээллийг тус Нөхөрлөлийн БХГ болон гаднын хөрөнгө оруулагчдад өгдөг.

Хязгаарлагдмал нөхөрлөл нь өөрийн үйл ажиллагааг явуулахаар заасан 10 жилийн хугацаанд эдгээр санхүүжигч нэг бүр дэх өөрийн хувь оролцоог худалдан борлуулахаар төлөвлөж байна. Ийм худалдан борлуулалтанд мөнгөөр шууд борлуулах, санхүүжигчдийн үнэт цаасыг олон нийтэд амжилттай санал болгосны дараа тэдгээр түргэн борлогдох өмчийн үнэт цааснуудыг хөрөнгө оруулагчдад борлуулан хуваарилах, хөрөнгө оруулалтыг олон нийтэд болон бусад хамааралгүй байгууллагуудад худалдан борлуулах үйл ажиллагаа хамаарна.

Өгөгдсөн мэдээллээс харахад, дараах нөхцлүүд хангагдаж байгаа учраас Хязгаарлагдмал нөхөрлөл нь анх үүсгэн байгуулагдсан 20X1 оноос эхлэн 20X3 оны 12 дугаар сарын 31 хүртэлх хугацаанд хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг хангаж байна:

- (а) Хязгаарлагдмал нөхөрлөл нь бүрэн бус хариуцлагатай гишүүдээс мөнгө санг хүлээн авч, тэдгээр бүрэн бус хариуцлагатай гишүүдэд хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлсэн;
- (б) Хязгаарлагдмал нөхөрлөлийн эрхэлдэг цорын ганц үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын хугацаанд капиталын үнийн өсөлтөөс ашиг олох зорилготойгоор тэдгээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын өмчийн хувь оролцоог олж эзэмших явдал юм. Хязгаарлагдмал нөхөрлөл нь бүхэлдээ өмчийн хөрөнгө оруулалтуудаас бүрдсэн өөрийн хөрөнгө оруулалтын хувьд гарах стратегийг тодорхойлж, баримтжуулсан байна; ба
- (в) Хязгаарлагдмал нөхөрлөл нь өөрийн хөрөнгө оруулалтаа бодит үнэ цэнийн сууриар үнэлж, хэмждэг бөгөөд энэхүү санхүүгийн мэдээллийг хөрөнгө оруулагчдад тайлагнадаг.

Түүнчлэн, Хязгаарлагдмал нөхөрлөл нь хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг хангаж буй эсэхийг үнэлэхэд хамааралтай дараах шинж чанаруудтай байна:

- (а) Хязгаарлагдмал нөхөрлөлд маш олон хөрөнгө оруулагч нар мөнгө сангаа оруулсан; ба
- (б) Капиталын хувь оролцоогоор дамжуулан олж эзэмшсэн уг нөхөрлөлийн хувь оролцооны нэгжүүд нь тус Хязгаарлагдмал нөхөрлөл дэх өмчлөлийг илэрхийлдэг.

Хязгаарлагдмал нөхөрлөл нь тухайн тайлант үед нэгээс олон хөрөнгө оруулалтыг эзэмшдэггүй. Гэвч энэ нь тус нөхөрлөл үйл ажиллагааны эхлэлийн шатанд байгаа бөгөөд тохиромжтой хөрөнгө оруулалтын боломжуудыг тодорхойлоогүй байсантай холбоотой юм.

**Жишээ 46**

“Технологи” корпораци нь технологийн эхлэлийн шатанд буй компаниудад хөрөнгө оруулж, капиталын үнийн өсөлтөөс ашиг олох зорилгоор Өндөр Технологийн Санг үүсгэн байгуулсан. Технологи корпораци нь уг Өндөр Технологийн Сангийн 70 хувийг эзэмшдэг бөгөөд түүнийг хянадаг; Өндөр Технологийн Сангийн үлдсэн 30 хувийг өөр арван хөрөнгө оруулагч нар эзэмшдэг. Технологи корпораци нь Өндөр Технологийн Сангийн эзэмшиж буй хөрөнгө оруулалтыг худалдан авах опционыг эзэмшдэг бөгөөд хэрэв тэдгээр санхүүжигчдийн боловсруулсан технологи нь Технологи корпорацийн үйл ажиллагаанд өгөөж бий болгохоор бол уг опционыг бодит үнэ цэнээр хэрэгжүүлэх юм. Өндөр Технологийн Сангийн тодорхойлсон хөрөнгө оруулалтуудаас гарах төлөвлөгөөгүй байна. Өндөр Технологийн Сангийн хөрөнгө оруулагчдын өмнөөс төлөөлөн оролцогчийн үүрэг гүйцэтгэж буй хөрөнгө оруулалтын зөвлөгч нь уг Өндөр Технологийн Санг удирддаг.

Хэдийгээр Өндөр Технологийн Сангийн зорилго нь капиталын үнийн өсөлтийн төлөө хөрөнгө оруулах явдал бөгөөд өөрийн хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлдэг боловч тус Өндөр Технологийн Сан нь дараах тохиролцоо ба нөхцөл байдлын улмаас хөрөнгө оруулалтын байгууллага биш юм:

- (а) Эдгээр санхүүжигч байгууллагуудын боловсруулсан хөрөнгө нь Технологи корпорацийн үйл ажиллагаанд өгөөж бий болгохоор байвал Өндөр Технологийн Сангийн хяналт тавигч байгууллага болох Технологи корпораци нь тэрхүү Өндөр Технологийн Сангийн эзэмшиж буй хөрөнгө оруулалтанд хамаарах хөрөнгө оруулалтуудыг худалдан авах опционыг эзэмшдэг. Энэ нь капиталын үнийн өсөлт буюу хөрөнгө оруулалтын орлогоос гадна өгөөж бүрдүүлэх юм; ба
- (б) Өндөр Технологийн Сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь өмчийн хөрөнгө оруулалтууд болох өөрийн хөрөнгө оруулалтын хувьд гарах стратегийг тусгаагүй байна. Технологи корпорацийн эзэмшиж буй опционыг уг Өндөр Технологийн Сан хянадаггүй бөгөөд энэ нь гарах стратегийг орлон бий болгохгүй.

**Жишээ 47**

Жижиглэн худалдаа, оффис болон бусад арилжааны үл хөдлөх хөрөнгүүдийг хөгжүүлэх, өмчлөх ба ажиллуулах зорилгоор Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллагыг үүсгэн байгуулсан. Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллага нь бүрэн өмчлөлт, хяналтанд буй тусдаа байгууллагуудаар дамжуулан өөрийн үл хөдлөх хөрөнгийг ихэвчлэн өмчилдэг бөгөөд тэдгээр тусдаа байгууллагууд нь уг холбогдох хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг санхүүжүүлэхэд ашигласан зээлээс өөр бусад ямар нэг мэдэгдэхүйц хөрөнгө буюу өр төлбөр байхгүй. Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллага ба түүний хяналтанд буй байгууллага нэг бүр нь өөрсдийн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг

УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх*-ийн дагуу бодит үнэ цэнээр тайлагнадаг. Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах тогтоосон цаг хугацаагүй боловч худалдан борлуулах хамгийн оновчтой хугацааг тодорхойлоход туслахын тулд бодит үнэ цэнийг ашигладаг. Хэдийгээр бодит үнэ цэнэ нь гүйцэтгэлийн нэг үзүүлэлт боловч Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллага ба түүний хөрөнгө оруулагч нар нь гүйцэтгэлийг үнэлж, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахын тулд бусад хэмжүүрүүдийг, үүн дотроо хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ, түрээсийн орлого ба зардлын талаархи мэдээллийг ашигладаг. Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллагын эрх бүхий албан тушаалтан нь бодит үнэ цэнийн мэдээллийг түүний хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үнэлэх хэмжилтийн анхдагч шинж тэмдэг гэж үздэггүй боловч мөн адил хамааралтай гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийн бүлгийн нэг хэсэг гэж үздэг.

Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллага нь үл хөдлөх хөрөнгийн болон хөрөнгийн менежментийн томоохон үйл ажиллагааг, үүн дотроо үл хөдлөх хөрөнгийн засвар үйлчилгээ, капитал зарлага, дахин хөгжүүлэлт, маркетинг, хөлслөгчдийн сонголт зэрэг үйл ажиллагааг эрхлэн явуулдаг бөгөөд үүний заримыг гуравдагч этгээдэд аутсорсинг байдлаар үзүүлдэг. Үүнд: шинэчлэн сайжруулах үл хөдлөх хөрөнгийн сонголт, хөгжүүлэлт, түүнчлэн ийм үл хөдлөх хөрөнгийг хөгжүүлэхийн тулд зураг зохиомж ба барилгын ажлын хувьд нийлүүлэгчидтэй хийх хэлцэл зэрэг хамаардаг. Энэхүү хөгжүүлэлтийн үйл ажиллагаа нь тус Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллагын үйл ажиллагааны бие даасан томоохон нэг хэсэг болдог.

Дараах учир шалтгааны улмаас Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг хангадаггүй:


- (а) Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллага нь өөрийн үл хөдлөх хөрөнгийн багцын идэвхитэй менежменттэй холбоотой бие даасан томоохон үйл ажиллагаатай байна. Үүнд: капиталын үнийн өсөлт буюу хөрөнгө оруулалтын орлогоос, эсвэл эдгээрийн аль алианаас өөр бусад байдлаар өгөөж бий болгох түрээсийн хэлцэл, шинэчлэн сайжруулалт ба хөгжүүлэлтийн үйл ажиллагаа хамаарна;
- (б) Тус Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллагын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь өөрийн хөрөнгө оруулалтын хувьд тусгайлан заасан гарах стратегигүй байна. Иймээс Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллага нь тэдгээр хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тодорхой бус хугацаагаар эзэмшихээр төлөвлөдөг; ба
- (в) Үл Хөдлөх Хөрөнгийн Байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг УСНББОУС 16-гийн дагуу бодит үнэ цэнээр тайлагнадаг боловч бодит үнэ цэнэ нь өөрийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үнэлэхийн тулд удирдлагын ашигладаг хэмжилтийн анхдагч шинж тэмдэг биш юм. Гүйцэтгэлийг үнэлж,

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа гүйцэтгэлийн бусад үзүүлэлтүүдийг ашигладаг.

### Жишээ 48

Мастер Сан гэдэг байгууллагыг 20X1 онд 10 жилийн хугацаатай байгуулсан. Мастер Сангийн өмчийг харилцан холбоотой хоёр дэд сан эзэмшдэг. Хууль эрх зүйн, зохицуулалтын, татварын болон адилтгах шаардлагуудыг ханган биелүүлэхийн тулд эдгээр дэд сангуудыг өөр хооронд нь харилцан уялдаатайгаар байгуулсан. Эдгээр дэд сангуудыг бүрэн хариуцлагатай гишүүний 1 хувийн хөрөнгө оруулалт, уг бүрэн хариуцлагатай гишүүнтэй харилцан холбоогүй бусад, өмчийн хөрөнгө оруулагчдын 99 хувийн хөрөнгө оруулалтаар (аль ч тал нь хяналт тавих санхүүгийн хувь оролцоог эзэмшдэггүй) байгуулсан.



Мастер Сангийн зорилго нь капиталын үнийн өсөлт ба хөрөнгө оруулалтын орлого (ногдол ашиг, хүү, түрээсийн орлого гэх мэт) бий болгохын тулд хөрөнгө оруулалтын багцыг эзэмших явдал юм. Мастер-Дэд гэсэн сангийн бүтцийн цорын ганц зорилго бол зах зээлийн тусдаа хэсэгт байгаа хөрөнгө оруулагчдад том хэмжээний хөрөнгийн багцад хөрөнгө оруулалт хийх боломж олгох явдал юм гэж тухайн хөрөнгө оруулалтын зорилгыг тэдгээр хөрөнгө оруулагчдад танилцуулан мэдэгдсэн. Мастер Сан нь өөрийн эзэмшиж буй өмчийн болон санхүүгийн бус хөрөнгө оруулалтын хувьд гарах стратегиудыг тодорхойлж, баримтжуулсан. Мастер Сан нь богино болон дунд хугацаатай өрийн хөрөнгө оруулалтын багцыг эзэмшдэг бөгөөд тэдгээрийн заримыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшдэг, заримыг нь худалдан арилждаг боловч чухам аль хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших, аль хөрөнгө оруулалтыг арилжих эсэхийг тусгайлан тодорхойлоогүй. Мастер Сан нь өөрийн бараг бүх хөрөнгө

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

оруулалтыг, үүн дотроо өрийн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнийн сууриар хэмжиж, үнэлдэг. Түүнчлэн, хөрөнгө оруулагч нар нь бодит үнэ цэнэд суурилсан үечилсэн санхүүгийн мэдээллийг тэдгээр дэд сангуудаас хүлээн авдаг. Мастер Сан болон дэд сангуудын аль алины өмчлөлийг өмчийн нэгжүүдээр илэрхийлдэг.

Мастер Сан болон дэд сангууд нь тус бүрдээ хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг хангадаг. Дараах нөхцөлтэй байсан:

- (а) Мастер Сан ба дэд сангуудын аль аль нь хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор мөнгө санг хүлээн авсан;
- (б) Дэд сангуудын хөрөнгө оруулагч нар шууд хүргэн танилцуулсан, Мастер-Дэд гэсэн сангийн бүтцийн зорилго бол зөвхөн капиталын үнийн өсөлт ба хөрөнгө оруулалтын орлого олохын тулд хөрөнгө оруулалт хийх явдал бөгөөд Мастер Сан нь өөрийн өмчийн болон санхүүгийн бус хөрөнгө оруулалтуудын хувьд гарах боломжит стратегиудыг тодорхойлж, баримтжуулсан;
- (в) Дэд сангууд нь Мастер Сан дахь өөрсдийн хувь оролцооны хувьд гарах стратегийг тодорхойлоогүй боловч Мастер Санг тэдгээр дэд сангуудтай уялдаа холбоотойгоор үүсгэн байгуулсан бөгөөд Мастер Сан нь дэд сангуудын өмнөөс хөрөнгө оруулалтыг эзэмшдэг тул дэд сангууд нь ямартаа ч өөрсдийн хөрөнгө оруулалтын хувьд гарах стратегитай гэж үзэж болох юм; ба
- (г) Мастер Сангийн эзэмшиж буй хөрөнгө оруулалтуудыг бодит үнэ цэнийн сууриар хэмжиж, үнэлдэг бөгөөд Мастер Сангийн хийсэн хөрөнгө оруулалтын талаархи мэдээллийг дэд сангуудаар дамжуулан бодит үнэ цэнийн сууриар хөрөнгө оруулагчдад хүргэн танилцуулдаг.

Хууль эрх зүйн, зохицуулалтын, татварын болон адилтгах шаардлагуудын улмаас Мастер Сан ба дэд сангуудыг өөр хооронд нь харилцан уялдаатайгаар үүсгэн байгуулсан. Хамтад нь авч үзвэл эдгээр нь дараах шинж чанартай байна:

- (а) Мастер Сан нь хөрөнгө оруулалтын багцыг эзэмшдэг тул дэд сангууд нь нэгээс олон хөрөнгө оруулалтыг шууд бусаар эзэмшдэг;
- (б) Мастер Санг дэд сангууд бүрэн эзэмшдэг боловч эдгээр дэд сангуудтай (болон бүрэн хариуцлагатай гишүүнтэй) холбоогүй олон тооны хөрөнгө оруулагчид нь дэд сангуудыг санхүүжүүлдэг; ба
- (в) Дэд сангуудын өмчлөлийг капиталын хувь оролцоогоор дамжуулан олж эзэмшсэн өмчийн хувь оролцооны нэгжүүдээр төлөөлөн илэрхийлдэг.

**Жишээ 49**

Одоо байгаа болон шинээр байгуулагдах аж ахуйн нэгжүүдэд өмчийн санхүүжилт олгох үндсэн үйл ажиллагаа бүхий Засгийн газрын А корпорацийг үүсгэн байгуулсан. Түүний хөрөнгө оруулалтын зорилго нь капиталын үнийн өсөлт ба хөрөнгө оруулалтын өгөөж олох явдал юм. Бүх худалдан авалтыг ийм үндэслэлээр хийдэг. Тус Корпорацийн стратеги нь худалдан борлуулалтаас олз олохын тулд хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг нэмэгдүүлэх явдал байдаг. Удирдлага нь хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тогтмол үнэлж, хянан зохицуулдаг. Тус Корпораци нь хөрөнгө оруулалтын дуусгавар болох хугацааны тодорхой үе шатанд хүрсэн үед хөрөнгө оруулалтыг тогтмол худалдан борлуулдаг бөгөөд ингэснээр тасралтгүй хөрөнгө оруулалт хийх боломжит мөнгө санг бүрдүүлдэг. Аливаа ашгийг ногдол ашиг хэлбэрээр Засгийн газарт хуваарилдаг.

Мөн уг Корпораци нь санхүүгийн хямралтай байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад туслах төрийн бодлогын дагуу хөрөнгө оруулалттай холбоотой үйлчилгээг Засгийн газарт үзүүлдэг. Тус Корпораци нь бизнесийг дэмжин урамшуулах Засгийн газрын хөтөлбөрийн зарим хэсгийг удирдан зохицуулах ба хэрэгжүүлэх төлөөлөн оролцогчийн үүргийг гүйцэтгэдэг. Уг Корпораци нь эдгээр хөтөлбөр дэх өөрийн оролцооны улмаас ямар нэг алдагдал буюу эрсдэл хүлээдэггүй.

Тус Корпораци нь хөрөнгө оруулалтын байгууллага юм. Энэ нь хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтын бүх гурван төлөв байдлыг ханган биелүүлдэг.

## СТОУС 10-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-г СТОУС 10, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* (2011 онд гаргасан, үүн дотроо 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан)-гаас үндсэндээ бэлтгэсэн болно. Энэ Стандартыг гаргах үед УСНББОУСЗ нь СТОУС 10-д дурдсан зарим СТОУС-уудын улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжтой байдлыг харгалзан үзээгүй байсан. Үүнд дараах стандартууд хамаарна:

- СТОУС 5, *Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа*; ба
- СТОУС 9, *Санхүүгийн Хэрэглүүр*

УСНББОУС 35 ба СТОУС 10-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 35 нь зарим тохиолдолд СТОУС 10-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь “эдийн засгийн нэгдмэл байгууллага”, “хяналт тавигч байгууллага”, “хяналтанд буй байгууллага” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. СТОУС 10 дахь адилтгах нэр томъёо нь “групп”, “толгой компани”, “охин компани” юм. СТОУС 10-д ашигласан “хөрөнгө оруулагч”, “санхүүжигч” гэсэн нэр томъёонуудыг олон тохиолдолд “байгууллага”, “бусад байгууллага” буюу “хяналтын зорилгоор үнэлэгдэж буй байгууллага” гэсэн хэллэгээр орлуулан хэрэглэсэн. “Хөрөнгө оруулагч”, “санхүүжигч” гэсэн нэр томъёонууд нь тухайн хам сэдэвт илүү тохиромжтой байсан тулд хөрөнгө оруулалтын байгууллагын талаархи мөрдөх заавар удирдамжид эдгээр нэр томъёог хэвээр ашигласан.
- УСНББОУС 35 нь “заавал биелүүлэх хэлцэл” нэр томъёог тодорхойлсон. Энэхүү нэр томъёо нь СТОУС 10-д ашигласан “гэрээний тохиролцоо” нэр томъёоноос илүү өргөн утгатай юм.
- СТОУС 10 нь хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн нийтлэг шинжүүдийг хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн тодорхойлолтоос тусад нь тодорхойлсон байдаг. Гэвч эдгээр шинжүүдийн заримыг уг хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн тодорхойлолтын хүрээнд авч үзсэн байдаг.
- УСНББОУС 35 нь санхүүгийн бус өгөөжийн талаархи илүү дэлгэрэнгүй заавар удирдамжийг агуулсан байдаг.
- Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэхийг УСНББОУС 35-аар шаарддаггүй. Харин ийм хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулах бөгөөд үүнд: (i) уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь хөрөнгө оруулалтаа УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих, ба (ii) хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг УСНББОУС 35-ын дагуу нэгтгэхийг энэхүү Стандартаар шаарддаг.



## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- УСНББОУС 35 нь улсын секторын нөхцлийг тусгасан нэмэлт үлгэрчилсэн жишээг агуулсан байдаг.

## УСНББОУС 36–ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР ДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 28, *Хараат Компани ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 28-аас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

**УСНББОУС 36–ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН  
ҮЙЛДВЭР ДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

**УСНББОУС-ЫН ТҮҮХ**

*Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.*

УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт-ыг 2015 оны 01 дүгээр сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 36-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)

**УСНББОУС 36-гийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт**

<b>Өөрчлөгдсөн параграф</b>	<b>Хэрхэн өөрчилсөн</b>	<b>Юугаар өөрчилсөн</b>
4	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
6	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
7	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
26	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
31	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
33	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
34А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
34Б	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
51А	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
51Б	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
51В	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар

2015 оны 01 дүгээр сар

**УСНББОУС 36–ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА  
ХАМТАРСАН  
ҮЙЛДВЭР ДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

**АГУУЛГА**

---

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-7
Тодорхойлолт	8-9
Заавал биелүүлэх хэлцэл	9
Мэдэгдэхүйц нөлөө	10-15
Өмчийн арга	16-21
Өмчийн аргын хэрэглээ	22-48
Өмчийн арга ашиглахаас чөлөөлөгдөх	23-25
Өмчийн арга хэрэглэхийг зогсоох	26-27
Өмчлөлийн хувь оролцооны өөрчлөлт	28
Өмчийн аргыг хэрэглэх горимууд	29-42
Үнэ цэнийн бууралтын гарз	43-48
Тусдаа санхүүгийн тайлан	49
Шилжилтийн нөхцөл	50
Хүчин төгөлдөр болох хугацаа	51-52
УСНББОУС 7 (2006 оны 12 дугаар сар)-гоос татгалзах ба орлуулах	53
Дүгнэлтийн үндэслэл	
НББОУС 28 (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-тай харьцуулалт	

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ыг 1-53-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 36-г түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэхүү Стандартын зорилго нь хараат байгууллага ба хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын нягтлан бодох бүртгэлийг тодорхойлох, хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг бүртгэх үед өмчийн аргыг хэрэглэх шаардлагуудыг тогтоох явдал юм.

## Цар хүрээ

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг тайлагнахдаа энэхүү Стандартыг мөрдөнө.**
3. **Хөрөнгө оруулалт нь тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцооны эзэмшилтэнд хүргэдэг тохиолдолд санхүүжигчийн хувьд хамтын хяналттай эсвэл мэдэгдэхүйц нөлөөтэй хөрөнгө оруулагч болох бүх байгууллагууд нь энэхүү Стандартыг мөрдөнө.**
4. Энэхүү Стандарт нь хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх өмчлөлийн хувь оролцооны нягтлан бодох бүртгэлийн суурь үндэслэлийг бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл, бусад байгууллага дахь хөрөнгө оруулалт нь өмчлөлийн хувь оролцоонд хамаарах эрсдэл ба өгөөжийг тухайн байгууллагад бий болгож байдаг. Зөвхөн тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоонд энэ Стандартыг мөрдөнө. Үүнд бусад байгууллагын өмчийн албан ёсны бүтцэд оруулсан хөрөнгө оруулалтаас үүсэх өмчлөлийн хувь оролцоонд хамаарна. Өмчийн албан ёсны бүтэц нь хувьцаат капитал буюу үл хөдлөх хөрөнгийн итгэмжлэгдсэн сангийн нэгж эрх гэх мэт капиталын адилтгах хэлбэр гэсэн үг юм. Тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоо нь тухайн байгууллагын өмчлөлийн хувь оролцоог найдвартай<sup>1</sup> хэмжиж болох бусад хөрөнгө оруулалтуудаас бий болсон өмчлөлийн хувь оролцоог (жишээлбэл; нөхөрлөлийн хувь оролцоог) бас агуулсан байж болно. Бусад байгууллагын өмчийн бүтцийг сайн тодорхойлоогүй бол уг өмчлөлийн хувь оролцооны найдвартай хэмжилтийг хийх боломжгүй байж болох юм.
5. Улсын секторын байгууллагуудын хийсэн зарим хувь оролцоог “хөрөнгө оруулалт” гэж үзэж болох боловч өмчлөлийн хувь оролцоо үүсгэдэггүй байж болно. Жишээлбэл; улсын секторын байгууллага нь буяны байгууллагын өмчилж, эрхлэн ажиллуулах эмнэлгийн барилгын ажилд томоохон хөрөнгө оруулалт хийж болох юм. Ийм хувь оролцоо нь арилжааны бус мөн чанартай боловч энэ нь тухайн эмнэлгийн үйл ажиллагаанд уг улсын секторын байгууллага оролцох боломж олгох бөгөөд

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

буяны байгууллага нь төрийн мөнгөний ашиглан зарцуулалтын хувьд тэрхүү улсын секторын байгууллагын өмнө хариуцлага хүлээдэг. Гэвч буяны байгууллага нь өөр хувилбар санхүүжилтийг авч болох бөгөөд ингэснээр эмнэлгийн үйл ажиллагаанд уг улсын секторын байгууллага оролцоход саад учруулж чадах учраас улсын секторын байгууллагын оруулсан хувь оролцоо нь өмчлөлийн хувь оролцоог бий болгохгүй байна. Иймээс уг улсын секторын байгууллага нь өмчлөлийн хувь оролцоотой холбоотойгоор эрсдэл хүлээхгүй, мөн өгөөж хүртэхгүй юм.

6. [Хассан]

7. [Хассан]

## Тодорхойлолт

8. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Хараат байгууллага** гэж хөрөнгө оруулагч нь түүнд мэдэгдэхүйц нөлөөтэй байх байгууллага юм.

**Заавал биелүүлэх хэлцэл:** Энэ Стандартын зорилгын хувьд заавал биелүүлэх хэлцэл нь хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адил хууль ёсны хүчин төгөлдөр эрх, үүргийг бий болгодог хэлцэл юм. Энэ нь гэрээгээр үүссэн эрх болон бусад хууль ёсны эрхийг агуулсан байдаг.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлан** гэдэг нь хяналт тавигч байгууллага болон түүний хяналтанд буй байгууллагуудын хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг эдийн засгийн нэг нэгж байдлаар толилуулдаг тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайлан юм.

**Өмчийн арга** гэдэг нь хөрөнгө оруулалтыг эхлээд өртгөөр хүлээн зөвшөөрөх ба үүний дараа уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн санхүүжигчийн цэвэр хөрөнгө/өмч дэх тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоонд тэрхүү худалдан авалтаас хойш гарсан өөрчлөлтийн хувьд тохируулга хийдэг нягтлан бодох бүртгэлийн арга юм. Хөрөнгө оруулагчийн ашиг, алдагдал нь санхүүжигчийн ашиг, алдагдалд өөрийн эзлэх хувь хэмжээг агуулсан байх бөгөөд тухайн хөрөнгө оруулагчийн цэвэр хөрөнгө/өмч нь уг санхүүжигчийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөөгүй тэрхүү санхүүжигчийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтөд өөрийн эзлэх хувь хэмжээг агуулсан байна.

**Хамтын хэлэлцээр** гэдэг нь хамтын хяналт бүхий хоёр буюу хэд хэдэн талуудын хоорондох хэлэлцээр юм.

**Хамтын хяналт** гэдэг нь хэлэлцээрийн хувьд заавал биелүүлэх хэлцлээр тохирсон хамтарсан хяналт бөгөөд холбогдох үйл

ажиллагааны талаархи шийдвэр нь уг хамтын хяналт бүхий талуудын санал нэгтэй зөвшөөрлийг шаарддаг зөвхөн тийм тохиолдолд уг хяналт хэрэгждэг.

Хамтарсан үйлдвэр гэдэг нь хэлэлцээрийн хувьд хамтын хяналт бүхий талууд нь тухайн хэлэлцээрийн цэвэр хөрөнгөнд хамаарах тодорхой эрхтэй байдаг тийм хамтын хэлэлцээр юм.

Хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч гэдэг нь хамтарсан үйлдвэрт хамтын хяналттай, уг хамтарсан үйлдвэрийн оролцогч тал юм.

Мэдэгдэхүйц нөлөө гэдэг нь бусад байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт оролцох бүрэн эрхтэй боловч тэдгээр бодлогыг хянадаггүй буюу хамтран хянадаггүй байхыг хэлнэ.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно. Дараах нэр томъёог УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-т тодорхойлсон. Үүнд: өгөөж, хяналт, хяналтанд буй байгууллага, хяналт тавигч байгууллага, эдийн засгийн нэгдмэл байгууллага, хөрөнгө оруулалтын байгууллага, хамтын үйл ажиллагаа, бүрэн эрх, тусдаа санхүүгийн тайлан.

### Заавал биелүүлэх хэлцэл

9. Заавал биелүүлэх хэлцлийг хэд хэдэн арга замаар нотлон харуулж болно. Заавал биелүүлэх хэлцлийг байнга биш боловч ихэвчлэн бичгээр үйлдэх бөгөөд талуудын хоорондох гэрээ эсвэл баримтжуулсан тохиролцоо хэлбэртэй байдаг. Хууль тогтоох эсвэл засаглах бүрэн эрх гэх мэт хуулиар тогтоосон механизм нь гэрээний тохиролцоотой адилаар хуулийн дагуу хүчин төгөлдөр болох хэлцлийг дангаараа, эсвэл талуудын хоорондох гэрээтэй холбоотойгоор мөн үүсгэн бий болгодог.

### Мэдэгдэхүйц нөлөө

10. Хөрөнгө оруулагч нь санхүүжигчийн хувьд мэдэгдэхүйц нөлөөтэй эсэх нь тухайн хөрөнгө оруулагч ба санхүүжигчийн хоорондох харилцааны шинж төрөл болон энэ Стандартад заасан, мэдэгдэхүйц нөлөөний тодорхойлолтод үндэслэсэн шүүн тунгаалтын асуудал юм. Байгууллага нь хувьцааны эзэмшилт буюу өмчийн бусад албан ёсны бүтэц хэлбэрээр эсвэл тухайн байгууллагын хувь оролцоог найдвартай хэмжиж чадах бусад хэлбэрээр тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоог нь эзэмшдэг зөвхөн тэдгээр хараат байгууллагуудын хувьд энэ Стандартыг мөрдөнө.
11. Хэрэв байгууллага нь тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоог эзэмшдэг бөгөөд санхүүжигчийн саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг шууд эсвэл шууд бусаар (жишээлбэл; хяналтанд буй байгууллагуудаар дамжуулан) эзэмшиж байвал мэдэгдэхүйц нөлөөгүй



гэдгээ илэрхий нотлон харуулж чадахаас бусад тохиолдолд тухайн байгууллага нь мэдэгдэхүйц нөлөөтэй гэж үзнэ. Эсрэг тохиолдолд байгууллага нь санхүүжигчийн саналын эрхийн 20 буюу түүнээс доош хувийг шууд эсвэл шууд бусаар (жишээлбэл; хяналтанд буй байгууллагуудаар дамжуулан) эзэмшиж байвал мэдэгдэхүйц нөлөөтэй гэдгээ илэрхий нотлон харуулахаас бусад тохиолдолд тухайн байгууллага нь мэдэгдэхүйц нөлөөгүй гэж үзнэ. Өөр хөрөнгө оруулагч мэдэгдэхүйц буюу олонхийн өмчлөлтэй байх нь тухайн байгууллагын мэдэгдэхүйц нөлөөтэй байдлыг заавал үгүйсгэхгүй юм.

12. Байгууллагын мэдэгдэхүйц нөлөө оршин байгааг дараах нэг буюу хэд хэдэн арга замаар ихэвчлэн нотолдог:
  - (а) Санхүүжигчийн захирлуудын зөвлөл буюу түүнтэй адилтгах эрх мэдэл бүхий засаглах удирдлагад төлөөлөлтэй байх;
  - (б) Бодлого боловсруулах үйл явцад оролцоотой байх, үүнд ногдол ашиг буюу бусад хуваарилалтын талаархи шийдвэр гаргалтанд оролцох;
  - (в) Тухайн байгууллага ба түүний санхүүжигчийн хоорондох материаллаг ажил гүйлгээ;
  - (г) Удирдах боловсон хүчний харилцан солилцоо; эсвэл
  - (д) Нэн чухал техникийн мэдээллээр хангадаг байх.
13. Аль нэг байгууллага нь хувьцааны баталгаа, хувьцааг буцаах опцион, энгийн хувьцаанд хөрвөх боломжтой өрийн буюу өмчийн хэрэглүүр, хэрэв хэрэгжүүлэх буюу хөрвүүлвэл нөгөө байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын хувьд нэмэлт саналын эрхийг тухайн байгууллагад өгөх эсвэл нөгөө талын саналын эрхийг бууруулах боломжтой (өөрөөр хэлбэл, боломжит саналын эрхтэй) адилтгах бусад хэрэглүүрүүдийг өмчилдөг байж болох юм. Байгууллага мэдэгдэхүйц нөлөөтэй эсэхийг үнэлэх үедээ одоо хэрэгжиж эсвэл хөрвүүлж болох боломжит саналын эрхийн, үүн дотроо бусад байгууллагуудын эзэмшиж буй боломжит саналын эрхийн оршин байдал ба үр нөлөөг харгалзан үздэг. Боломжит саналын эрх нь тухайлбал, ирээдүйн тодорхой нэг хугацаа хүртэл эсвэл ирээдүйн үйл явдал тохиолдох хүртэл хэрэгжиж эсвэл хөрвөж чадахгүй тохиолдолд түүнийг одоо хэрэгжиж эсвэл хөрвөж болох саналын эрх гэж үзэхгүй.
14. Боломжит саналын эрх нь мэдэгдэхүйц нөлөөнд хувь нэмрээ оруулах эсэхийг үнэлэхдээ тухайн байгууллага нь тэдгээр боломжит эрхийг хэрэгжүүлэх буюу хөрвүүлэх удирдлагын хүсэл сонирхол ба санхүүгийн боломж чадавхиас бусад уг боломжит эрхэд нөлөө үзүүлэх бүх баримт материал болон нөхцөл байдлуудыг (үүнд боломжит саналын эрхийг хэрэгжүүлэх нөхцөл, мөн тус тусад нь, эсвэл хамтад нь авч үзэх гэрээний аливаа бусад тохиролцоог) харгалзан үзнэ.
15. Байгууллага нь санхүүжигчийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын шийдвэр гаргалтад оролцох эрхээ алдсан тохиолдолд уг

санхүүжигчид үзүүлэх мэдэгдэхүйц нөлөөгөө алдсан гэж үзнэ. Өмчлөлийн үнэмлэхүй дүн эсвэл хувийн жингийн хэмжээнд өөрчлөлт орсноор эсвэл ийм өөрчлөлт орохгүйгээр мэдэгдэхүйц нөлөөгөө алдаж болох юм. Тухайлбал; хараат байгууллага нь өөр засгийн газар, шүүх буюу төрийн захиргааны байгууллагын хяналтанд орсон тохиолдолд ийм нөхцөл байдал үүсэж болно. Мөн заавал биелүүлэх хэлцлийн үр дүнд мэдэгдэхүйц нөлөө алдагдаж болох юм.

## Өмчийн арга

16. Өмчийн аргын дагуу, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр бүртгэх бөгөөд тэрхүү худалдан авалтаас хойш санхүүжигчийн ашиг, алдагдалд тухайн хөрөнгө оруулагчийн эзлэх хувь хэмжээг хүлээн зөвшөөрөхийн тулд уг дансны үнийг нэмэгдүүлэх буюу бууруулдаг. Санхүүжигчийн ашиг, алдагдалд хөрөнгө оруулагчийн эзлэх хувь хэмжээг уг хөрөнгө оруулагчийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Санхүүжигчээс хүлээн авсан хуваарилалтаар тухайн хөрөнгө оруулалтын дансны үнийг бууруулдаг. Санхүүжигчийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөөгүй түүний өмчийн өөрчлөлтийн улмаас үүссэн тухайн санхүүжигч дэх уг хөрөнгө оруулагчийн харгалзах хувь оролцооны өөрчлөлтийн хувьд дансны үнийг мөн тохируулах шаардлагатай байж болох юм. Ийм өөрчлөлтөнд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ болон гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүгээс үүссэн өөрчлөлт хамаардаг. Эдгээр өөрчлөлтийн хувьд тухайн хөрөнгө оруулагчид хамаарах хувь хэмжээг уг хөрөнгө оруулагчийн цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.
17. Хүлээн авсан хуваарилалт нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн гүйцэтгэлтэй хамаарал багатай байж болох учраас тэрхүү хүлээн авсан хуваарилалтанд үндэслэн орлогыг хүлээн зөвшөөрөх нь тухайн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтаас уг хөрөнгө оруулагчийн олсон орлогын зохих хэмжүүр болж чадахгүй байж болох юм. Хөрөнгө оруулагч нь санхүүжигчийн хувьд хамтын хяналттай буюу мэдэгдэхүйц нөлөөтэй байдаг тул уг хөрөнгө оруулагч нь тухайн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн гүйцэтгэлд хувь оролцоотой бөгөөд иймээс өөрийн хөрөнгө оруулалтаас үр өгөөж хүртэнэ. Хөрөнгө оруулагч нь тухайн санхүүжигчийн ашиг, алдагдалд өөрийн эзлэх хувь хэмжээгээ тусган оруулахын тулд санхүүгийн тайлангийн цар хүрээгээ өргөжүүлэх замаар энэхүү хувь оролцоогоо тайлагнадаг. Иймээс өмчийн аргыг хэрэглэх нь хөрөнгө оруулагчийн цэвэр хөрөнгө/өмч ба ашиг, алдагдлын талаар илүү их мэдээлэл бүхий тайлагналаар хангадаг.
18. Боломжит саналын эрх эсвэл боломжит саналын эрхийг агуулсан өөр бусад үүсмэл хэрэглүүр байгаа тохиолдолд хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх тухайн байгууллагын хувь оролцоо нь зөвхөн одоо байгаа өмчлөлийн хувь оролцоонд үндэслэн тодорхойлогдох бөгөөд 19-р параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд тэрхүү боломжит саналын эрх болон бусад үүсмэл хэрэглүүрийн боломжит хэрэгжилт эсвэл хөрвүүлэлтийг тусган илэрхийлэхгүй.

19. Зарим тохиолдолд, өмчлөлийн хувь оролцоотой холбоотой өгөөжийг одоо хүртэх боломжийг олгодог ажил гүйлгээний үр дүнд уг байгууллага нь мөн чанарын хувьд одоогийн өмчлөлтэй болсон байдаг. Ийм тохиолдолд өгөөжийг одоо хүртэх боломжийг тухайн байгууллагад олгодог тэдгээр боломжит саналын эрхийн зохих хэрэгжилт ба бусад үүсмэл хэрэглүүрийг харгалзан үзсэнээр уг байгууллагад хуваарилагдах хувь хэмжээг тодорхойлно.
20. Өмчийн аргыг ашиглан тайлагнадаг хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны хувьд УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийг мөрдөхгүй. Боломжит саналын эрхийг агуулсан хэрэглүүр нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өмчлөлийн хувь оролцоотой холбоотой өгөөжийг мөн чанарын хувьд одоо хүртэх боломж олгодог тохиолдолд уг хэрэглүүрийг УСНББОУС 29-өөр зохицуулахгүй. Бусад бүх тохиолдолд, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх боломжит саналын эрхийг агуулсан хэрэглүүрүүдийг УСНББОУС 29-ийн дагуу тайлагнана.
21. **Өмчийн аргыг ашиглан тайлагнадаг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг эргэлтийн бус хөрөнгө гэж ангилна.**

### **Өмчийн аргын хэрэглээ**

22. **Хөрөнгө оруулалт нь 23-25-р параграфт заасан чөлөөлөгдөх шалгуурыг хангадаг байхаас бусад тохиолдолд санхүүжигчийн хувьд хамтын хяналттай эсвэл мэдэгдэхүйц нөлөөтэй байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн хөрөнгө оруулалтыг өмчийн арга ашиглан тайлагнана.**

### **Өмчийн арга ашиглахаас чөлөөлөгдөх**

23. Хэрэв байгууллага нь УСНББОУС 35-ын 5-р параграфт дурдсан цар хүрээний хязгаарлах заалтын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахаас чөлөөлөгддөг хяналт тавигч байгууллага бол, эсвэл дараах бүх нөхцлүүд хангагдсан тохиолдолд тухайн байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн хөрөнгө оруулалтын хувьд өмчийн аргыг хэрэглэх шаардлагагүй юм:
  - (а) Байгууллага нь өөрөө хяналтанд буй байгууллага бөгөөд хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг түүний хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар хангадаг ба хэсэгчлэн өмчилдөг байгууллагын хувьд түүний бусад бүх эздэд, үүн дотроо саналын эрхгүй эздэд уг байгууллага өмчийн арга хэрэглэхгүй байгаа талаар мэдэгдсэн ба тэд эсэргүүцээгүй;
  - (б) Байгууллагын өрийн буюу өмчийн хэрэглүүрийг хөрөнгийн зах зээл (дотоодын буюу гадаадын хөрөнгийн бирж, орон нутгийн болон бүс нутгийн албан бус зах зээл)-д арилжаалдаггүй;

- (в) Байгууллага нь хөрөнгийн зах зээлд ямар нэг санхүүгийн хэрэглүүр гаргах зорилгоор өөрийн санхүүгийн тайланг үнэт цаасны хороо буюу бусад зохицуулагч байгууллагад танилцуулаагүй, мөн ингэж танилцуулахаар бэлтгээгүй; ба
  - (г) Байгууллагын хамгийн эцсийн эсвэл завсрын аль нэг хяналт тавигч байгууллага нь УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг олон нийтэд зориулан гаргадаг бөгөөд УСНББОУС 35-ын дагуу уг тайланд хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэдэг буюу бодит үнэ цэнээр нь хэмждэг.
24. Жижиг дунд үйлдвэрт хөрөнгө оруулагч байгууллагууд, хамтын сан, хамтын итгэлцлийн сан болон тэдгээртэй адилтгах байгууллагууд, үүн дотроо хөрөнгө оруулалттай хосолсон даатгалын сан гэх мэт байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг шууд ба шууд бусаар эзэмшдэг тохиолдолд уг байгууллага нь тэдгээр хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийж болно. Тодорхойлолт ёсоор хөрөнгө оруулалтын байгууллага нь ийм сонголтыг хийнэ.
25. Байгууллага нь хараат байгууллагад хөрөнгө оруулалттай бөгөөд түүний тодорхой хэсгийг жижиг дунд үйлдвэрт хөрөнгө оруулагч байгууллагууд, хамтын сан, хамтын итгэлцлийн сан болон тэдгээртэй адилтгах байгууллагууд, үүн дотроо хөрөнгө оруулалттай хосолсон даатгалын сангаар дамжуулан шууд бусаар эзэмшдэг тохиолдолд уг жижиг дунд үйлдвэрт хөрөнгө оруулагч байгууллагууд, хамтын сан, хамтын итгэлцлийн сан болон тэдгээртэй адилтгах байгууллагууд, үүн дотроо хөрөнгө оруулалттай хосолсон даатгалын сан нь хөрөнгө оруулалтын тухайн хэсгийн хувьд мэдэгдэхүйц нөлөөтэй эсэхээс үл хамааран тухайн байгууллага нь хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын тэрхүү хэсгийг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийж болно. Хэрэв байгууллага нь ийм сонголт хийвэл тэдгээр жижиг дунд үйлдвэрт хөрөнгө оруулагч байгууллагууд, хамтын сан, хамтын итгэлцлийн сан болон тэдгээртэй адилтгах байгууллагууд, үүн дотроо хөрөнгө оруулалттай хосолсон даатгалын сангийн эзэмшдэггүй уг хараат байгууллага дахь түүний хөрөнгө оруулалтын аливаа үлдсэн хэсгийн хувьд тухайн байгууллага нь өмчийн аргыг хэрэглэнэ. Байгууллага нь хараат байгууллагад хөрөнгө оруулалттай бөгөөд түүний тодорхой хэсгийг хөрөнгө оруулалтын байгууллагаар дамжуулан шууд бусаар эзэмшдэг тохиолдолд тухайн байгууллага нь хөрөнгө оруулалтын тэрхүү хэсгийг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ.

#### **Өмчийн арга хэрэглэхийг зогсоох**

26. **Байгууллагын хөрөнгө оруулалт нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр байхаа больсон өдрөөс эхлэн тухайн байгууллага нь өмчийн арга хэрэглэхийг дараах байдлаар зогсооно:**

- (a) Хэрэв хөрөнгө оруулалт нь хяналтанд буй байгууллага болсон бол тухайн байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл ба УСНББОУС 35-ын дагуу тайлагнана.
  - (б) Хэрэв өмнөх хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх үлдсэн хувь оролцоо нь санхүүгийн хөрөнгө бол байгууллага нь уг үлдсэн хувь оролцоог бодит үнэ цэнээр хэмжинэ. Уг үлдсэн хувь оролцооны бодит үнэ цэнийг УСНББОУС 29-ийн дагуу санхүүгийн хөрөнгө гэж анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ гэж үзнэ. Байгууллага нь үлдсэн хувь оролцоог бодит үнэ цэнээр хэмжихийг УСНББОУС 29-ийн МЗУ113 ба МЗУ114-р параграфтаар хориглодог тохиолдолд тэрхүү хөрөнгө оруулалт нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр байхаа больсон өдрөөс эхлэн тус байгууллага нь уг үлдсэн хувь оролцоог тухайн хөрөнгө оруулалтын дансны үнээр хэмжих бөгөөд энэхүү дансны үнийг УСНББОУС 29-ийн дагуу санхүүгийн хөрөнгө гэж анх хүлээн зөвшөөрөх үеийн өртөг гэж үзнэ. Байгууллага нь дараах дүнгүүдийн хоорондох аливаа зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:
    - (i) Аливаа үлдсэн хувь оролцооны, түүнчлэн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны тодорхой хэсгийг данснаас хассаны аливаа мөнгөн орлогын бодит үнэ цэнэ (буюу хамааралтай тохиолдолд дансны үнэ); ба
    - (ii) Өмчийн арга хэрэглэхийг зогсоосон өдрөөрх тухайн хөрөнгө оруулалтын дансны үнэ.
  - (в) Байгууллага нь өмчийн арга хэрэглэхээ зогсоосон тохиолдолд уг хөрөнгө оруулалттай холбоотойгоор тэрхүү байгууллагын цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь шууд хүлээн зөвшөөрч байсан бүх дүнг, хэрэв санхүүжигч нь холбогдох бүх хөрөнгө буюу өр төлбөрөө шууд данснаас хассан бол шаардах байсантай ижил сууриар тухайн байгууллага нь тайлагнана.
27. Хэрэв хараат байгууллага дахь хөрөнгө оруулалт нь хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт болсон эсвэл хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт нь хараат байгууллага дахь хөрөнгө оруулалт болсон бол тухайн байгууллага нь өмчийн аргаа үргэлжлүүлэн хэрэглэх бөгөөд уг үлдсэн хувь оролцоог дахин хэмжихгүй.

#### **Өмчлөлийн хувь оролцооны өөрчлөлт**

28. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх тухайн байгууллагын өмчлөлийн хувь оролцоо буурсан боловч уг хөрөнгө оруулалтыг хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэр гэж тус тус ангилсан хэвээр байгаа тохиолдолд хэрэв холбогдох хөрөнгө, өр төлбөрийг данснаас хассанаар түүний олз, гарзыг хуримтлагдсан ашиг, алдагдалд шууд шилжүүлэхийг шаардах байсан бол цэвэр хөрөнгө/өмчид өмнө нь хүлээн зөвшөөрч байсан

олз, гарзын тэрхүү өмчийн хувь оролцооны бууралттай холбоотой хэсгийг тухайн байгууллага нь хуримтлагдсан ашиг, алдагдалд шууд шилжүүлнэ.

**Өмчийн аргыг хэрэглэх горимууд**

29. Өмчийн аргын хэрэглээнд тохиромжтой олон горимууд нь УСНББОУС 35-д заасан нэгтгэлийн горимуудтай ижил төсөөтэй байдаг. Түүнчлэн, хяналтанд буй байгууллагын худалдан авалтын бүртгэлд ашигладаг горимуудын суурь үндэслэл болох ойлголт ухагдахууныг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын худалдан авалтын бүртгэлд мөн адил мөрддөг.
30. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувь оролцоо нь хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй байгууллагуудын уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх эзэмшлийн хувь оролцооны нийлбэр байна. Харин уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын бусад хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн эзэмшлийг энэ зорилгын хувьд харгалзан тооцохгүй. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэртэй тохиолдолд өмчийн аргыг хэрэглэхдээ харгалзан үзэх ашиг алдагдал болон цэвэр хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлоготой нийцүүлэхэд шаардлагатай аливаа тохируулгын (37-39-р параграфыг үзнэ үү) дараах уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн харгалзах үзүүлэлтүүд (үүнд: түүний хараат байгууллага ба хамтарсан үйлдвэрийн ашиг алдагдал, цэвэр хөрөнгөнд тухайн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн эзлэх хувь оролцоо) юм.
31. Байгууллага (үүнд түүний нэгтгэсэн, хяналтанд буй байгууллагууд хамаарна) болон түүний хараат байгууллага, эсвэл хамтарсан үйлдвэрийн хооронд гарсан бөгөөд УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэхгүй хөрөнгүүдтэй холбоотой “дээш чиглэсэн” ба “доош чиглэсэн” ажил гүйлгээний олз, гарзыг уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн хувьд холбоогүй тал болох зөвхөн тэдгээр хөрөнгө оруулагчдын хувь оролцооны хэмжээгээр тухайн байгууллагын санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө. “Дээш чиглэсэн” ажил гүйлгээ нь тухайлбал, хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэрээс хөрөнгийг тухайн хөрөнгө оруулагчид борлуулах ажил гүйлгээ юм. Ийм ажил гүйлгээнээс үүссэн, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн олз, гарзын хувьд тухайн байгууллагын эзлэх хувь хэмжээг устган цэвэрлэдэг. “Доош чиглэсэн” ажил гүйлгээ нь тухайлбал, хөрөнгө оруулагчаас өөрийн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт хөрөнгө борлуулах ажил гүйлгээ юм.
32. Доош чиглэсэн ажил гүйлгээ нь уг борлуулсан буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн цэвэр боломжит үнэ цэнэ буурсан эсвэл тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэдгийн нотолгоо болж байгаа тохиолдолд хөрөнгө оруулагч нь тэдгээр гарзыг бүхэлд нь хүлээн зөвшөөрнө. Дээш чиглэсэн ажил гүйлгээ нь уг худалдан авсан хөрөнгийн цэвэр боломжит үнэ цэнэ буурсан эсвэл тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз үүссэн

гэдгийн нотолгоо болж байвал хөрөнгө оруулагч нь тэдгээр гарзаас зөвхөн өөрт ногдох хэсгийг хүлээн зөвшөөрнө.

33. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт өмчийн хувь оролцоотой болсны хариуд тэдгээр хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт өгсөн, гэхдээ УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэхгүй, мөнгөн зүйлсийн бус хөрөнгөөрх хувь нийлүүлэлт нь УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-д заасан нөхцлүүдийн дагуу арилжааны шинж чанарыг агуулаагүй байхаас бусад тохиолдолд уг хувь нийлүүлэлтээс үүссэн олз, гарзыг 31-р параграфын дагуу тайлагнана. Хэрэв ийм хувь нийлүүлэлт нь арилжааны шинж чанарыг агуулаагүй бол олз, гарзыг хэрэгжээгүй гэж үзэх бөгөөд 34-р параграфыг бас мөрдөхөөс бусад тохиолдолд уг олз, гарзыг хүлээн зөвшөөрөхгүй. Ийм хэрэгжээгүй олз, гарзыг өмчийн арга ашиглан тайлагнасан хөрөнгө оруулалтаас хасаж, устгах бөгөөд хөрөнгө оруулалтаа өмчийн арга ашиглан тайлагнадаг байгууллагын нэгтгэсэн буюу тусдаа санхүүгийн байдлын тайланд хойшлогдсон олз, гарз байдлаар толилуулахгүй.
34. Хэрэв байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өмчийн хувь оролцоог хүлээн авахаас гадна мөнгөн ба мөнгөн зүйлсийн бус хөрөнгийг хүлээн авсан бол уг байгууллага нь тэдгээр хүлээн авсан мөнгөн болон мөнгөн зүйлсийн бус хөрөнгүүдтэй холбоотой тухайн хувь нийлүүлэлтийн хувьд олз, гарзын тэрхүү хэсгийг бүхэлд нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- 34А. Байгууллага (үүнд түүний нэгтгэсэн, хяналтанд буй байгууллагууд хамаарна) болон түүний хараат байгууллага, эсвэл хамтарсан үйлдвэрийн хооронд гарсан бөгөөд УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэхгүй хөрөнгүүдтэй холбоотой “доош чиглэсэн” ажил гүйлгээний олз, гарзыг уг хөрөнгө оруулагчийн санхүүгийн тайланд бүхэлд нь хүлээн зөвшөөрнө.
- 34Б. Байгууллага нь хоёр буюу хэд хэдэн хэлцлээр (ажил гүйлгээгээр) хөрөнгөө борлуулж эсвэл хувь нийлүүлж болох юм. Борлуулсан эсвэл хувь нийлүүлсэн хөрөнгө нь УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэх эсэхийг тогтоохдоо байгууллага нь тэдгээр хөрөнгийн борлуулалт буюу хувь нийлүүлэлт нь УСНББОУС 35-ын 53-р параграфын шаардлагуудын дагуу нэг ажил гүйлгээ байдлаар тайлагнавал зохих олон хэлцлийн нэг хэсэг мөн эсэхийг харгалзан үзнэ.
35. Хөрөнгө оруулалт нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр болох тохиолдолд уг өдрөөс эхлэн түүнийг өмчийн арга ашиглан тайлагнана. Хөрөнгө оруулалтыг худалдан авах үед тухайн хөрөнгө оруулалтын өртөг ба санхүүжигчийн тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн цэвэр бодит үнэ цэнэд уг байгууллагын эзлэх хувь хэмжээний хоорондох аливаа зөрүүг дараах байдлаар тайлагнана:

- (а) Байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэртэй холбоотой гүүдвилийг тухайн хөрөнгө оруулалтын дансны үнэд оруулдаг тохиолдолд уг гүүдвилийг хорогдуулахыг зөвшөөрөхгүй.
- (б) Санхүүжигчийн тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн цэвэр бодит үнэ цэнэд байгууллагын эзлэх хувь хэмжээ нь тухайн хөрөнгө оруулалтын өртгөөс давж, илүү гарсан аливаа дүнг тэрхүү хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн ашиг, алдагдалд байгууллагын эзлэх хувь хэмжээг тодорхойлохдоо уг хөрөнгө оруулалтыг худалдан авсан тайлант үед орлого байдлаар тусгана.

Худалдан авалтаас хойшхи ажил гүйлгээг тайлагнахын тулд хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн ашиг, алдагдалд уг байгууллагын эзлэх хувь хэмжээнд зохих тохируулгыг хийнэ. Тухайлбал; уг худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэд нь үндэслэн бүртгэсэн, элэгдүүлэх хөрөнгийн элэгдлийг бүртгэхийн тулд тохируулга хийдэг. Үүнтэй адилаар, тухайн худалдан авалтаас хойшхи үндсэн хөрөнгө, хэрэв хамааралтай бол гүүдвил гэх мэт хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хувьд хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн ашиг, алдагдалд уг байгууллагын эзлэх хувь хэмжээнд зохих тохируулгыг хийнэ.

**36. Өмчийн аргыг хэрэглэх үедээ байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн бэлэн байгаа хамгийн сүүлийн тайлант үеийн санхүүгийн тайланг ашиглана. Тухайн байгууллагын тайлант үеийн эцэс нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн тайлант үеийн эцсээс өөр бол тус байгууллага нь:**

- (а) Өмчийн аргыг хэрэглэх зорилгоор байгууллагын санхүүгийн тайлангийн өдөртэй адил өдрөөр санхүүгийн нэмэлт мэдээллийг олж авна; эсвэл
- (б) Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн хамгийн сүүлийн санхүүгийн тайлангийн өдөр ба тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн өдрийн хооронд гарч тохиолдсон томоохон ажил гүйлгээ, үйл явдлын үр нөлөөний хувьд тохируулга хийсэн тэрхүү хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн хамгийн сүүлийн үеийн санхүүгийн тайланг ашиглана.

**37. Төсөөтэй нөхцөл байдалд гарч тохиолдсон ижил ажил гүйлгээ ба үйл явдлуудын хувьд нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлогыг ашигласнаар тухайн байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэнэ.**

**38. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр нь төсөөтэй нөхцөл байдалд гарч тохиолдсон ижил ажил гүйлгээ ба үйл явдлуудын хувьд байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогоос өөр бодлогыг хэрэглэдэг бөгөөд тухайн байгууллага нь өмчийн аргыг хэрэглэх үүднээс уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн санхүүгийн тайланг ашигладаг бол 39-р параграфт зааснаас бусад тохиолдолд хараат байгууллага ба хамтарсан үйлдвэрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг энэхүү**



байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд тохируулга хийнэ.

39. **38-р параграфын шаардлагыг үл харгалзан, тухайн байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт хувь оролцоотой бол тэрхүү байгууллага нь өмчийн аргыг хэрэглэх үедээ уг хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр өөрийн хяналтанд буй байгууллагууд дахь хувь оролцоондоо хэрэглэдэг бодит үнэ цэнийн хэмжилтийг хэвээр хадгална.**
40. Хэрэв хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр нь эргэлтэнд гаргасан, хуримтлалтай давуу эрхийн хувьцаатай бөгөөд түүнийг тухайн байгууллагаас өөр бусад талууд эзэмшдэг ба өмч гэж ангилсан бол уг байгууллага нь ногдол ашиг зарласан эсэхээс үл хамааран тэдгээр давуу эрхийн хувьцаанд хамаарах ногдол ашгийн хувьд тохируулга хийсний дараах ашиг, алдагдлын хувьд өөрийн хувь хэмжээг тооцоолно.
41. Хэрэв хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн алдагдалд тухайн байгууллагын эзлэх хувь хэмжээ нь уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх түүний хувь оролцоотой тэнцүү болсон эсвэл давсан бол тус байгууллага нь цаашдын алдагдлын хувьд өөрт хамаарах хувь хэмжээг хүлээн зөвшөөрөхгүй, зогсооно. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо нь өмчийн аргыг ашиглан тодорхойлсон, уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын дансны үнэ, түүнчлэн мөн чанарын хувьд энэхүү хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх тухайн байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх аливаа урт хугацаат хувь оролцооны нийлбэр байна. Жишээлбэл; ойрын ирээдүйд буцаан төлөгдөхөөр төлөвлөгдөөгүй, мөн ингэж төлөгдөх магадлалгүй зүйлс нь мөн чанарын хувьд уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт тухайн байгууллагын оруулсан нэмэлт хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Ийм зүйлсэд давуу эрхтэй хувьцаа, урт хугацаат авлага буюу зээл багтах боловч дансны авлага, дансны өглөг эсвэл баталгаат зээл зэрэг зохих барьцаа хөрөнгө бүхий аливаа урт хугацаат авлага хамаарахгүй. Энгийн хувьцаанд оруулсан тухайн байгууллагын хөрөнгө оруулалтын дүнгээс давсан бөгөөд өмчийн арга ашиглан хүлээн зөвшөөрсөн алдагдлыг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх уг байгууллагын хувь оролцооны бусад бүрэлдэхүүн хэсгээс тэдгээрийн оруулсан хугацааны буурах дарааллаар (өөрөөр хэлбэл, хөрвөх чадварын өсөх дарааллаар) хасаж тусгана.
42. Байгууллагын хувь оролцоо тэг болтол буурснаас хойш нэмэлт алдагдал үүссэн бол тухайн байгууллага нь хуулийн буюу гэрээний бус үүрэг хүлээсэн эсвэл уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн өмнөөс төлбөр төлсөн зөвхөн тэр хэмжээгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Хэрэв хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр нь дараагийн тайлант үед ашиг тайлагнасан бол уг ашигт байгууллагын эзлэх хувь хэмжээ нь үүнээс өмнө хүлээн зөвшөөрөөгүй байсан алдагдалд түүний эзлэх хувь

хэмжээтэй тэнцүү болсон зөвхөн тэр үеэс хойш тухайн байгууллага нь тэдгээр ашигт эзлэх өөрийн хувь хэмжээг хүлээн зөвшөөрч эхэлнэ.

### Үнэ цэнийн бууралтын гарз

43. Өмчийн аргыг хэрэглэсэн, үүн дотроо хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн алдагдлыг 41-р параграфын дагуу хүлээн зөвшөөрснөөс хойш уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх түүний цэвэр хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнэ бууралтыг нэмж хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд тухайн байгууллага нь УСНББОУС 29-ийг мөрдөнө.
44. Байгууллага нь цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлдэггүй уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь оролцооны хувьд аливаа нэмэлт үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөх эсэх, түүнчлэн уг үнэ цэнийн бууралтын гарзын дүнг тодорхойлохын тулд УСНББОУС 29-ийг мөн мөрдөнө.
45. УСНББОУС 29-ийг мөрдөх аливаа тохиолдолд уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан байж болохыг илтгэн харуулж байвал тухайн байгууллага нь УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг, магадгүй УСНББОУС 21 *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг мөрдөнө.
46. Байгууллага нь мөнгө бий болгогч хөрөнгө оруулалтын ашиглалтын үнэ цэнийг хэрхэн тодорхойлохыг УСНББОУС 26-д заасан байдаг. Мөнгө бий болгогч хөрөнгө оруулалтын ашиглалтын үнэ цэнийг УСНББОУС 26-гийн дагуу тодорхойлохдоо тухайн байгууллага нь дараах зүйлсийг тооцоолно:
- (а) Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн бий болгохоор хүлээгдэж буй ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний, үүн дотроо уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн үйл ажиллагаанаас бий болох мөнгөн гүйлгээ болон тухайн хөрөнгө оруулалтыг эцэстээ борлуулснаас олох мөнгөн орлогын өнөөгийн үнэ цэнэд эзлэх өөрийн хувь хэмжээ; эсвэл
  - (б) Хөрөнгө оруулалтаас хүлээн авах ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтаас болон тухайн хөрөнгө оруулалтыг эцэстээ данснаас хассанаас бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ.
- Зохих таамаглалуудыг ашиглан тооцвол дээрх хоёр аргын аль аль нь ижил үр дүнд хүргэдэг.
47. Хэрэв хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүн нь түүний дансны үнээс бага бол уг дансны үнийг түүний нөхөгдөх үйлчилгээний дүн хүртэл бууруулахыг УСНББОУС 21-ээр шаардсан байдаг. Нөхөгдөх үйлчилгээний дүн нь тухайн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба ашиглалтын үнэ цэнийн аль их дүн байдаг. Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тухайн хөрөнгийн үлдэх үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ

цэнэ байдлаар тодорхойлдог. Үлдэх үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийг элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага, нөхөн сэргээлтийн өртгийн хандлага, үйлчилгээний нэгжийн хандлагын аль тохиромжтойг ашиглан үнэлж болох юм.

48. Тухайн байгууллагын бусад хөрөнгөөс бий болох мөнгөн гүйлгээнээс ихээхэн хамааралгүй байх өөрийн тасралтгүй үйл ажиллагаанаас уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр нь мөнгөн орлогын гүйлгээ үүсгэж чадахгүй байхаас бусад тохиолдолд хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтын нөхөгдөх дүнг тэдгээр хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр тус бүрээр үнэлнэ.

### **Тусдаа санхүүгийн тайлан**

49. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтыг УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*-гийн 12-р параграфын дагуу тухайн байгууллагын тусдаа санхүүгийн тайланд тайлагнана.

### **Шилжилтийн нөхцөл**

50. Хувь тэнцүүлэн нэгтгэх аргыг өмчийн арга болгон өөрчлөх, эсвэл өмчийн аргыг хамтын үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн тайлагнал болгон өөрчлөхтэй холбоотой шилжилтийн нөхцлүүдийг УСНББОУС 37-д заасан.

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

51. Байгууллага нь энэхүү Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 34, УСНББОУС 35, УСНББОУС 37, УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-ыг мөрдөнө.
- 51А. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 6, 7-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 51Б. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 26-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-

нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

- 51В. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 31, 33-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 34А, 34Б параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС3-өөс тодорхойлсон өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд гүйцээх горимоор мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дурдсан өдрөөс өмнө мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд хэрэв хараахан мөрдөөгүй байгаа бол тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
52. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## **УСНББОУС 7 (2006 оны 12 дугаар сар)-гоос татгалзах ба орлуулах**

53. Энэ Стандарт нь УСНББОУС 7, *Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт* (2006 оны 12 дугаар сар)-ыг орлоно. УСНББОУС 36-г мөрдөх эсвэл энэ Стандарт хүчин төгөлдөр болох хугацааны аль түрүүнд болох өдөр хүртэл УСНББОУС 7 нь мөрдөгдсөн хэвээр байна.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 36-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Зорилго

ДҮ1. УСНББОУС 36-гийн дүгнэлтүүдэд хүрэхдээ УСНББОУС3-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. Энэ Стандарт нь НББОУС3-өөс гаргасан, НББОУС 28, *Хараат Компани ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт* (2011 онд гаргасан ба үүн дотроо, 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүд)-д үндэслэсэн тул УСНББОУС 36 нь НББОУС 28 (2011 онд Нэмэлт өөрчлөлт оруулсан)-ын гол шаардлагуудаас гажсан эсвэл УСНББОУС3 нь ийм гажилтыг авч үзсэн зөвхөн тэдгээр талбаруудыг Дүгнэлтийн Үндэслэлд хамруулсан.

### Тойм

ДҮ2. УСНББОУС3 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны тайлагналыг зохицуулах УСНББОУС-уудыг шинэчлэх төслийн ажлыг 2012 онд эхэлсэн. *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцоо* гэж хамтад нь нэрлэх, Саналын Төсөл (СТ) 48-52-ыг УСНББОУС3 нь 2013 оны 10 дугаар сард гаргасан. СТ 50, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт* нь НББОУС 28 (2011 онд Нэмэлт өөрчлөлт оруулсан)-д үндэслэсэн бөгөөд УСНББОУС 7, *Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт*, УСНББОУС 8, *Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо* дахь улсын секторын холбогдох засвар өөрчлөлтүүдийг авч үзсэн. 2015 оны 01 дүгээр сард УСНББОУС3 нь шинэ таван УСНББОУС-ыг, үүн дотроо УСНББОУС 36-г гаргасан. Эдгээр шинэ УСНББОУС-ууд нь УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 7, УСНББОУС 8-ыг орлох юм.

ДҮ3. Хараат байгууллага ба хамтарсан үйлдвэрийн тайлагналыг нэгтгэсний үр дүнд энэ Стандартын нэрийг *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт* болгон өөрчилсөн.

ДҮ4. УСНББОУС 36-гийн төслийг боловсруулахдаа, Зөвлөл нь УСНББОУС 7, *Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт*-ын бүх шаардлагуудыг харгалзан үзээгүй. Хамгийн том өөрчлөлт нь хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг тайлагнахдаа өмчийн арга ашиглахыг шаардах, ингэснээр хараат байгууллага ба хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтуудын тайлагналыг нэг стандартад нэгтгэн оруулах шийдвэрийн үр дүн байсан. Хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг тайлагнахдаа өмчийн арга ашиглах талаархи Зөвлөлийн үзэл баримтлалыг УСНББОУС 37-гийн Дүгнэлтийн Үндэслэлд авч хэлэлцсэн.

**Үйл явц**

*Тоогоор илэрийлж болох өмчлөлийн хувь оролцоо*

- ДҮ5. “Хараат байгууллага дахь хөрөнгө оруулалт нь хувьцааны эзэмшилт буюу өмчийн бусад албан ёсны бүтэц хэлбэр бүхий өмчлөлийн хувь оролцооны эзэмшилтэд хүргэдэг” тохиолдолд УСНББОУС 7-гийн цар хүрээ нь хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтаар хязгаарлагдана гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Хараат байгууллага нь албан ёсны буюу бусад найдвартай хэмжиж болох өмчийн бүтэцтэй байхаас бусад тохиолдолд өмчийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэх магадлал багатай гэдгийг УСНББОУС3 нь УСНББОУС 7-г боловсруулах үедээ тэмдэглэсэн. УСНББОУС3 нь энэхүү засвар өөрчлөлтийн зорилгыг тусгасан ба өмчлөлийн хувь оролцооноос бусад хувь оролцоонд уг Стандартыг зохисгүй хэрэглэхээс сэргийлэх санаа зорилготой гэж дүгнэсэн.
- ДҮ6. УСНББОУС 7-гоос ялгаатай нь, энэ Стандартыг хараат байгууллага болон хамтарсан үйлдвэрийн аль алинд мөрдөнө. Хамтарсан үйлдвэр нь олон хэлбэртэй, үүн дотроо албан ёсны өмчийн бүтэцгүй нөхөрлөлийн хэлцэл хэлбэрээр байж болох учраас УСНББОУС 7-гийн цар хүрээний хязгаарлалт нь нь тохиромжгүй байсан. УСНББОУС3 нь энэ Стандартын цар хүрээг “тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоо”-гоор хязгаарлах хэрэгтэй гэж шийдвэрлэсэн. Хариулт өгсөн хүмүүс нь энэ саналыг дэмжсэн боловч бусад байгууллагууд дахь тухайн байгууллагын тоогоор илэрийлж болох өмчлөлийн хувь оролцооны талаархи мэдээллийг тодруулах нь тохиромжтой гэж үзсэн. УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга* нь тоолох боломжгүй өмчлөлийн хувь оролцооны тодруулга хийхийг шаардах хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн.

*Түр зуурын хяналт ба мэдэгдэхүйц нөлөө*

- ДҮ7. Бусад байгууллага дахь хамтын хяналт буюу мэдэгдэхүйц нөлөө нь түр зуурын байх төлөвтэй тохиолдолд УСНББОУС 7 ба УСНББОУС 8, *Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо* нь өмчийн арга эсвэл хувь тэнцүүлэн нэгтгэх арга хэрэглэхийг шаарддаггүй. НББОУС3 нь СТОУС 5, *Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа*-г гаргасны үр дүнд адилтгах СТОУС-уудаас эдгээр чөлөөлөх нөхцлийг 2003 онд хассан гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн.
- ДҮ8. УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-г боловсруулах үедээ УСНББОУС3 нь түр зуурын хяналтын чөлөөлөх нөхцлийг уг Стандартад оруулах эсэхтэй холбоотой асуудлыг авч үзсэн бөгөөд ингэж оруулахгүй байхыг зөвшөөрсөн. Иймээс УСНББОУС3 нь түр зуурын хамтын хяналт буюу түр зуурын мэдэгдэхүйц нөлөөнд үндэслэсэн чөлөөлөх нөхцлүүдийг УСНББОУС 36-д оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.

### **Мэдэгдэхүйц нөлөө**

ДҮ9. Хэрэв байгууллага нь хувьцааны эзэмшилт буюу өмчийн бусад албан ёсны бүтэц хэлбэрээр өмчлөлийн хувь оролцоог эзэмшдэг бөгөөд санхүүжигчийн саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг шууд эсвэл шууд бусаар (жишээлбэл; хяналтанд буй байгууллагуудаар дамжуулан) эзэмшиж байвал тухайн байгууллага нь санхүүжигчийн хувьд мэдэгдэхүйц нөлөөтэй байна гэсэн урьдчилсан нөхцлийг энэхүү Стандартаар тогтоосон. Мэдэгдэхүйц нөлөөний урьдчилсан нөхцлийг тогтоохдоо 20 хувийг ашиглах явдал нь НББОУС 28-аас анх үүсэлтэй бөгөөд үүнийг УСНББОУС 7 (2006 оны 12 дугаар сар)-д бас ашигласан гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Уг урьдчилсан нөхцлийг энэ Стандартад хэвээр хадгалах эсэхийг шийдвэрлэхдээ, УСНББОУС3 нь 20 хувиас өөр дүнг ашиглах улсын секторын аливаа учир шалтгаан байхгүй гэдгийг дурдсан.

### **Тайлагналын нийтлэг өдөр**

ДҮ10. Тухайн байгууллага болон түүний хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн тайлант үеийн эцсийн өдрүүдийн хоорондох зөрүүд хугацааны хязгаар тогтоох эсэхийг УСНББОУС3 харгалзан үзсэн. Өмчийн аргыг мөрдөхдөө тухайн байгууллага нь уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн бэлэн боломжтой байгаа хамгийн сүүлийн санхүүгийн тайланг ашиглах бөгөөд тэдгээр нь нэг ижил хугацаатай биш тохиолдолд залруулга хийхийг НББОУС 28-аар шаарддаг гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Түүнчлэн, НББОУС 28 нь тайлангийн өдрүүдийн хоорондох зөрүүг гурван сараас хэтрэхгүй байхаар хязгаарласан. Байгууллагууд нь тайлагналын өөр өөр өдрүүдтэй байх бөгөөд тэдгээр өдрүүдийг өөрчлөх боломжгүй тийм тохиолдол улсын секторт үүсэж болно гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Иймээс УСНББОУС3 нь хугацааны зөрүүний хувьд гурван сарын хязгаар тогтоохгүй байхыг зөвшөөрсөн.

### **Хөрөнгө оруулалтын байгууллагууд**

ДҮ11. Хөрөнгө оруулалтын байгууллагууд, түүнчлэн хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагч нар нь өмчийн аргыг хэрхэн мөрдөхийг тодруулахыг СТ 50-д хариулт өгсөн хүмүүс нь УСНББОУС3-өөс хүссэн. Иймээс УСНББОУС3 нь:

- (а) Тодорхойлолт ёсоор, хөрөнгө оруулалтын байгууллага нь хараат байгууллага ба хамтарсан үйлдвэр дэх өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тайлагнах сонголт хийнэ гэдгийг тодорхой болгосон; ба
- (б) Хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хөрөнгө оруулалтын байгууллага болох хамтарсан үйлдвэрт хувь оролцоотой байгууллага нь өмчийн аргыг мөрдөх үедээ тэрхүү хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хөрөнгө оруулалтын байгууллага болох хамтарсан үйлдвэрийн хэрэглэдэг бодит үнэ цэнийн хэмжилтийг хяналтанд буй

байгууллагууд дахь өөрийн хувь оролцооны хувьд хэвээр хадгалахыг шаардсан.

ДҮ12. НББОУСЗ-ийн бүрэлдэхүүн нь хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага болон хөрөнгө оруулалтын байгууллага болох хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын тайлагналын зарим төлөв байдлыг мөн тодруулахыг эрмэлзсэн гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. 2014 оны 6 дугаар сард НББОУСЗ нь СТ 2014/2 *Хөрөнгө Оруулалтын Аж Ахуйн Нэгжүүд: Нэгтгэлээс Чөлөөлөгдөх Заалтыг Мөрдөх (СТОУС 10, НББОУС 28-ын Санал болгосон нэмэлт өөрчлөлтүүд)*-ийг гаргасан ба үүний дараа 2014 оны 12 дугаар сард *Хөрөнгө Оруулалтын Аж Ахуйн Нэгжүүд: Нэгтгэлээс Чөлөөлөгдөх Заалтыг Мөрдөх (СТОУС 10, СТОУС 12, НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)*-ийг гаргасан. Эдгээр тодруулгууд нь НББОУСЗ-ийн хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн шаардлагуудыг дурдсан хугацаанаас өмнө мөрдөж буй аж ахуйн нэгжүүдийн тодорхойлсон, хэрэгжүүлэлтийн асуудлуудыг авч үзэхэд ач холбогдолтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн бөгөөд энэ Стандартад хамааралтай тэдгээр нэмэлт өөрчлөлтийн төлөв байдлуудыг харгалзан тусгасан.

**Хөрөнгө оруулагч ба түүний хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэрийн хоорондох хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлт**

ДҮ13. Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани буюу хамтарсан үйлдвэрийн хоорондох ажил гүйлгээний хувьд хэсэгчилсэн олз, гарз хүлээн зөвшөөрөх шаардлагуудыг СТОУС 3, *Бизнесийн Нэгдэл*-д тодорхойлсончлон, бизнесийг бүрдүүлдэггүй зөвхөн тийм хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлтээс үүсэх олз, гарзад мөрддөг болгохын тулд НББОУСЗ нь УСНББОУС 36-г боловсруулж байх энэ үед СТОУС 10 болон НББОУС 28-д нэмэлт өөрчлөлт оруулсан. НББОУСЗ нь *Хөрөнгө Оруулагч ба түүний Хараат Компани эсвэл Хамтарсан Үйлдвэрийн Хоорондох Хөрөнгийн Борлуулалт буюу Хөрөнгөөрх Хувь Нийлүүлэлт (СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)*-ийг 2014 оны 9 дүгээр сард гаргасан. Бүрэн буюу хэсэгчилсэн олз, гарзын хүлээн зөвшөөрөлтийг улсын секторын нэгдлүүдэд хамаарах стандартын түвшний шаардлагуудын төслийг боловсруулах хүрээнд харгалзан үзэх нь илүү тохиромжтой гэсэн үндэслэлээр УСНББОУСЗ нь эдгээр нэмэлт өөрчлөлтөөр илэрхийлэгдэх шаардлагуудыг УСНББОУС 35 ба УСНББОУС 36-д тусган оруулахгүй байхыг зөвшөөрсөн.

ДҮ14. СТ 60, *Улсын Секторын Нэгдэл*-ийг боловсруулж байх үедээ УСНББОУСЗ нь хөрөнгө оруулагч ба түүний хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэрийн хоорондох хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлтийг хэрхэн тайлагнах талаархи заавар удирдамжийг тусган оруулах эсэхийг дахин харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь НББОУСЗ-өөс гаргасан *Хөрөнгө Оруулагч ба түүний Хараат Компани эсвэл Хамтарсан Үйлдвэрийн Хоорондох Хөрөнгийн Борлуулалт буюу Хөрөнгөөрх Хувь Нийлүүлэлт (СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)*-



д тусгасан заавар удирдамжийг нягталж үзсэн. Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани буюу хамтарсан үйлдвэрийн хоорондох ажил гүйлгээний хэсэгчилсэн олз, гарз болох байсан уг НББОУСЗ-ийн нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэв УСНББОУС 36-д оруулан мөрдвөл түүний үр нөлөөг *үйл ажиллагааг агуулдаггүй* тэрхүү хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлтээс үүсэх олз, гарзад зөвхөн хамааруулан мөрдөнө. УСНББОУСЗ нь НББОУСЗ-ийн арга хандлагаас гажих, улсын секторын ямар нэг тусгай учир шалтгааныг тогтоогоогүй. Иймээс УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамжийг (СТ 60 дахь нэр томъёо ба тодорхойлолттой нийцүүлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулсан) УСНББОУС 36-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

ДҮ15. 2015 оны 12 дугаар сард НББОУСЗ нь *Хөрөнгө Оруулагч ба түүний Хараат Компани эсвэл Хамтарсан Үйлдвэрийн Хоорондох Хөрөнгийн Борлуулалт буюу Хөрөнгөөрх Хувь Нийлүүлэлт* (СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)-д тусгасан заавар удирдамжийн хэрэгжилтийг хойшлуулсан. Яагаад гэвэл, НББОУСЗ нь өмчийн нягтлан бодох бүртгэлийн талаархи өөрийн төслийн нэг хэсэг болгон энэхүү талбарт цаашдын судалгаа хийж байсан бөгөөд богино хугацааны дотор өөрсдийн нягтлан бодох бүртгэлд хоёр удаа өөрчлөлт оруулахыг аж ахуйн нэгжүүдээс шаардахыг хүсээгүй. Хүчин төгөлдөр болох хугацааг хойшлуулахдаа НББОУСЗ нь илүү сайн санхүүгийн тайлагналын мөрдөлтөнд саад учруулахыг хүсээгүй тул уг заавар удирдамжийн дурдсан хугацаанаас өмнө мөрдөлтийг зөвшөөрсөн хэвээр байсан. УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамжийн хэрэгжилтийг хойшлуулах НББОУСЗ-ийн шийдвэрийг нягталж үзсэн. УСНББОУСЗ нь НББОУСЗ-ийн арга хандлагаас гажих, улсын секторын ямар нэг тусгай учир шалтгааныг тогтоогоогүй. Иймээс УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамжийг (УСНББОУС 40 дэх нэр томъёо ба тодорхойлолттой нийцүүлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулсан) УСНББОУС 36-д тусган оруулж, УСНББОУСЗ-өөс тодорхойлсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг зөвшөөрсөн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 36-д хийсэн хянан засварлалт**

ДҮ16. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох*

ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР ДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

*Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.*

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **НББОУС 28 (2011 ОНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН)-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ**

УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ыг НББОУС 28, *Хараат Компани ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт* (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан, үүн дотроо 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан)-аас үндсэндээ бэлтгэсэн. Энэ Стандартыг гаргах үед УСНББОУСЗ нь СТОУС 9, *Санхүүгийн Хэрэглүүрийн* улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжтой байдлыг харгалзан үзээгүй байсан. Иймээс НББОУС 28 дахь СТОУС 9 гэсэн хэллэгүүдийг санхүүгийн хэрэглүүрүүдийг зохицуулдаг УСНББОУС-уудын нэрээр орлуулан хэрэглэсэн.

УСНББОУС 36 ба НББОУС 28 (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 36 нь зарим тохиолдолд НББОУС 28 (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь “цэвэр хөрөнгө/өмч”, “эдийн засгийн нэгдмэл байгууллага”, “хяналт тавигч байгууллага”, “хяналтанд буй байгууллага”, “орлого” /revenue/ гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 28 (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) дахь адилтгах нэр томъёо нь “өмч”, “групп”, “толгой компани”, “охин компани”, “орлого” /income/ юм.
- Хөрөнгө оруулагч нь тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоотой байх бүх хөрөнгө оруулалтын хувьд УСНББОУС 36-г дагаж мөрдөнө. Харин НББОУС 28 (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) нь үүнтэй адилтгах шаардлагыг агуулаагүй байдаг. Гэвч тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоотой байхаас бусад тохиолдолд уг өмчийн нягтлан бодох бүртгэлийг ашиглах магадлал багатай байдаг.
- Байгууллага нь өмнөх хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт хадгалж үлдсэн хувь оролцоогоо бодит үнэ цэнээр хэмжихийг УСНББОУС 29-өөр хориглодог тохиолдолд тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн өртөг болгон түүний дансны үнийг ашиглахыг УСНББОУС 36-гаар зөвшөөрсөн байдаг. НББОУС 28 (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) нь уг үлдсэн хувь оролцоог бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг.
- Хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт хувь оролцоотой байгууллага нь өмчийн аргыг хэрэглэх үедээ уг хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр өөрийн хяналтанд буй байгууллагууд дахь хувь оролцоондоо хэрэглэдэг бодит үнэ цэнийн хэмжилтийг хэвээр хадгалахыг УСНББОУС 36-гаар шаардсан байдаг. Хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат компани буюу хамтарсан үйлдвэрт хувь оролцоотой аж ахуйн нэгж нь тэрхүү хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат компани буюу хамтарсан үйлдвэрийн ашигладаг бодит үнэ

ХАРААТ БАЙГУУЛЛАГА БА ХАМТАРСАН ҮЙЛДВЭР ДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

цэнийн хэмжилтийг хэвээр хадгалахыг НББОУС 28 (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-аар зөвшөөрсөн байдаг.

## УСНББОУС 37–ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) 11, *Хамтын Хэлэлцээр*-ээс үндсэндээ бэлтгэсэн болно. СТОУС 11-ээс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 37-ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр-ийг 2015 оны 01 дүгээр сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 37-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нээдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 37-гийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
5	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
6	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
24А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
32	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
41А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
42А	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
42Б	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
42В	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
МЗУ33А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
МЗУ33Б	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
МЗУ33В	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
МЗУ33Г	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар

## УСНББОУС 37–ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

## АГУУЛГА

	Параграф
Зорилго	1-2
Цар хүрээ	3-6
Тодорхойлолт	7-8
Заавал биелүүлэх хэлцэл	8
Хамтын хэлэлцээр	9-22
Хамтын хяналт	12-18
Хамтын хэлэлцээрийн төрлүүд	19-22
Хамтын хэлэлцээрийн оролцогч талуудын санхүүгийн тайлан	23-28
Хамтын үйл ажиллагаа	23-26
Хамтарсан үйлдвэр	27-28
Тусдаа санхүүгийн тайлан	29-30
Шилжилтийн нөхцөл	31-41
Хамтарсан үйлдвэр – Хувь тэнцүүлэн нэгтгэх аргаас өмчийн аргад шилжих	32-36
Хамтын үйл ажиллагаа – Өмчийн аргаас хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах аргад шилжих	37-40
Байгууллагын тусдаа санхүүгийн тайлан дахь шилжилтийн нөхцлүүд	41
Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын тайлагнал	41А
Хүчин төгөлдөр болох хугацаа	42-43
УСНББОУС 8 (2006 оны 12 дугаар сар)-аас татгалзах ба орлуулах	44
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Үлгэрчилсэн жишээ	
СТОУС 11-тэй харьцуулалт	

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 37, *Хамтын Хэлэлцээр*-ийг 1-44-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 37-г түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.



## Зорилго

1. Энэхүү Стандартын зорилго нь хамтран хянадаг хэлэлцээр (өөрөөр хэлбэл, хамтын хэлэлцээр)-т хувь оролцоотой байгууллагуудын санхүүгийн тайлагналын хувьд зарчмуудыг тогтооход оршино.
2. 1-р параграфт дурдсан зорилгыг ханган биелүүлэхийн тулд энэ Стандарт нь хамтын хяналтыг тодорхойлсон бөгөөд өөрийн эрх, үүргийг үнэлэх замаар тухайн оролцсон хамтын хэлэлцээрийнхээ төрлийг тодорхойлох, түүнчлэн уг хамтын хэлэлцээрийн төрлийн дагуу тэдгээр эрх, үүргээ тайлагнахыг хамтын хэлэлцээрийн оролцогч тал болох байгууллагаас шаарддаг.

## Цар хүрээ

3. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь өөрийн оролцсон хамтын хэлэлцээрийн төрлийг тодорхойлох ба уг хамтын хэлэлцээрийн эрх, үүргийг тайлагнахдаа энэ Стандартыг мөрдөнө.
4. Хамтын хэлэлцээрийн оролцогч тал болох бүх байгууллагууд нь энэ Стандартыг дагаж мөрдөнө.
5. [Хассан]
6. [Хассан]

## Тодорхойлолт

7. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Заавал биелүүлэх хэлцэл:** Энэ Стандартын зорилгын хувьд заавал биелүүлэх хэлцэл нь хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адил хууль ёсны хүчин төгөлдөр эрх, үүргийг бий болгодог хэлцэл юм. Энэ нь гэрээгээр үүссэн эрх болон бусад хууль ёсны эрхийг агуулсан байдаг.

**Хамтын хэлэлцээр** гэдэг нь хамтын хяналт бүхий хоёр буюу хэд хэдэн талуудын хоорондох хэлэлцээр юм.

**Хамтын хяналт** гэдэг нь хэлэлцээрийн хувьд заавал биелүүлэх хэлцлээр тохирсон хамтарсан хяналт бөгөөд холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэр нь уг хамтын хяналт бүхий талуудын санал нэгтэй зөвшөөрлийг шаарддаг зөвхөн тийм тохиолдолд уг хяналт хэрэгждэг.

**Хамтын үйл ажиллагаа** гэдэг нь хэлэлцээрт хамтын хяналт тавьдаг оролцогч талууд нь тэрхүү хэлэлцээртэй холбоотойгоор хөрөнгийн

хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй байдаг хамтын хэлэлцээр юм.

Хамтын үйл ажиллагаа эрхлэгч гэдэг нь хамтын үйл ажиллагаанд хамтын хяналттай, уг хамтын үйл ажиллагааны оролцогч тал юм.

Хамтарсан үйлдвэр гэдэг нь хэлэлцээрийн хувьд хамтын хяналт бүхий талууд нь тухайн хэлэлцээрийн цэвэр хөрөнгөнд хамаарах тодорхой эрхтэй байдаг тийм хамтын хэлэлцээр юм.

Хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч гэдэг нь хамтарсан үйлдвэрт хамтын хяналттай, уг хамтарсан үйлдвэрийн оролцогч тал юм.

Хамтын хэлэлцээрийн оролцогч тал гэдэг нь хамтын хэлэлцээрт оролцдог байгууллага бөгөөд энэ нь уг хэлэлцээрт тухайн байгууллага хамтын хяналттай эсэхээс үл хамаарна.

Тусдаа бүтэц гэж тусад нь тодорхойлж болох санхүүгийн бүтэц, үүн дотроо, хууль тогтоомжоор зөвшөөрсөн эрх зүйн этгээд буюу этгээдүүд, гэхдээ тэдгээр этгээд нь хуулийн этгээдийн эрхтэй эсэхээс үл хамаарна.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь-д* дахин нийтэлсэн болно. Дараах нэр томъёог УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт-д* тодорхойлсон. Үүнд: өгөөж, хяналт, өмчийн арга, бүрэн эрх, хамгаалалтын эрх, холбогдох үйл ажиллагаа, тусдаа санхүүгийн тайлан, мэдэгдэхүйц нөлөө.

#### Заавал биелүүлэх хэлцэл

8. Заавал биелүүлэх хэлцлийг хэд хэдэн арга замаар нотлон харуулж болно. Заавал биелүүлэх хэлцлийг байнга биш боловч ихэвчлэн бичгээр үйлдэх бөгөөд талуудын хоорондох гэрээ эсвэл баримтжуулсан тохиролцоо хэлбэртэй байдаг. Хууль тогтоох эсвэл засаглах бүрэн эрх гэх мэт хуулиар тогтоосон механизм нь гэрээний тохиролцоотой адилаар хуулийн дагуу хүчин төгөлдөр болох хэлцлийг дангаараа эсвэл талуудын хоорондох гэрээтэй холбоотойгоор мөн үүсгэн бий болгодог.

#### Хамтын хэлэлцээр (МЗУ2-МЗУ33-р параграфыг үзнэ үү)

9. Хамтын хэлэлцээр нь хоёр буюу хэд хэдэн талууд хамтын хяналттай байх хэлэлцээр юм.
10. Хамтын хэлэлцээр нь дараах шинж чанартай байна:

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

- (а) Талууд нь заавал биелүүлэх хэлцлээр харилцан холбогддог (МЗУ2-МЗУ-р параграфыг үзнэ үү).
- (б) Заавал биелүүлэх хэлцэл нь уг хэлэлцээрийн хамтын хяналтыг тэдгээр хоёр буюу хэд хэдэн талуудад олгодог (12-18-р параграфыг үзнэ үү).

11. Хамтын хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа эсвэл хамтарсан үйлдвэр байна.

### Хамтын хяналт

- 12. Хамтын хяналт нь тухайн хэлэлцээрийн хяналтын хуваалт бөгөөд холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэр нь уг хяналтыг хуваан хэрэгжүүлж буй талуудын санал нэгтэй зөвшөөрлийг шаарддаг зөвхөн тийм тохиолдолд хамтын хяналт оршин байна.
- 13. Хэлэлцээрийн оролцогч тал болох байгууллага нь хэлэлцээрийн хяналтыг бүх талуудад буюу талуудын бүлэгт уг заавал биелүүлэх хэлцлээр хамтарсан байдлаар олгодог эсэхийг үнэлнэ. Бүх талууд буюу талуудын бүлэг нь уг хэлэлцээрийн (өөрөөр хэлбэл, холбогдох үйл ажиллагааны) өгөөжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлэхдээ хамтран ажиллах шаардлагатай тохиолдолд тэд тухайн хэлэлцээрийг хамтарсан байдлаар хянадаг.
- 14. Бүх талууд буюу талуудын бүлэг нь уг хэлэлцээрийг хамтарсан байдлаар хянадаг гэж тодорхойлсон бол холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэр нь тухайн хэлэлцээрийг хамтарсан байдлаар хянадаг талуудын санал нэгтэй зөвшөөрлийг шаарддаг зөвхөн тийм тохиолдолд хамтын хяналт оршин байна.
- 15. Хамтын хэлэлцээрийн үед аль нэг тал нь уг хэлэлцээрийг дангаараа хянахгүй. Хэлэлцээрт хамтын хяналт бүхий тал нь бусад аль нэг тал буюу талуудын бүлэг тухайн хэлэлцээрийг хянахаас сэргийлж чаддаг.
- 16. Хэдийгээр хэлэлцээрийн бүх талууд нь хамтын хяналт тавьдаггүй боловч тухайн хэлэлцээр нь хамтын хэлэлцээр байж болно. Энэ Стандарт нь хамтын хэлэлцээрт (хамтын үйл ажиллагаа эсвэл хамтарсан үйлдвэрт) хамтын хяналттай талууд ба уг хамтын хэлэлцээрт оролцох боловч хамтын хяналтгүй талуудыг ялган тодорхойлдог.
- 17. Бүх талууд буюу талуудын бүлэг нь уг хэлэлцээрт хамтын хяналттай эсэхийг үнэлэх үедээ байгууллага нь шүүн тунгаалт хийх шаардлагатай болдог. Байгууллага нь бүх баримт материал болон нөхцөл байдлуудыг харгалзан үзсэнээр энэхүү үнэлгээг хийдэг (МЗУ5-МЗУ11-р параграфыг үзнэ үү).
- 18. Баримт материал болон нөхцөл байдал өөрчлөгдсөн бол байгууллага нь тухайн хэлэлцээрийн хувьд хамтын хяналттай хэвээр байгаа эсэхээ дахин үнэлнэ.

**Хамтын хэлэлцээрийн төрлүүд**

19. **Байгууллага нь өөрийн оролцсон хамтын хэлэлцээрийн төрлийг тодорхойлно. Хамтын хэлэлцээрийг хамтын үйл ажиллагаа эсвэл хамтарсан үйлдвэр гэж ангилах ангилал нь тухайн хэлэлцээрийн оролцогч талуудын эрх, үүргээс хамаардаг.**
20. **Хамтын хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа эсвэл хамтарсан үйлдвэр эсэхийг үнэлэхдээ байгууллага нь шүүн тунгаалт хийнэ. Байгууллага нь өөрийн оролцсон хэлэлцээрээс үүсэх эрх, үүргийг харгалзан үзсэнээр тухайн хамтын хэлэлцээрийн төрлийг тодорхойлно. Байгууллага нь уг хэлэлцээрийн бүтэц, зохион байгуулалт ба хуулийн хэлбэр, талуудын тохиролцсон болон хууль тогтоох эсвэл засаглах бүрэн эрхээр тогтоосон нөхцлүүд, мөн хамааралтай бол бусад баримт материал, нөхцөл байдлуудыг харгалзан үзсэнээр өөрийн эрх, үүргийг үнэлдэг (МЗУ12-МЗУ33-р параграфыг үзнэ үү).**
21. **Нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааг гүйцэтгэх гэрээний ерөнхий нөхцлүүдийг заасан, урьдчилсан гэрээгээр зарим үед талуудын хооронд харилцаа үүсдэг. Тухайн хэлэлцээрийн нэг хэсэг болох тодорхой үйл ажиллагаануудыг эрхлэн явуулахын тулд талууд нь өөр өөр хамтын хэлэлцээр байгуулахаар уг урьдчилсан гэрээнд заасан байж болно. Хэдийгээр тэдгээр хамтын хэлэлцээрүүд нь нэг урьдчилсан гэрээтэй холбоотой боловч тэрхүү урьдчилсан гэрээнд тусгагдсан янз бүрийн үйл ажиллагааг эрхлэн явуулах үед талуудын эрх, үүрэг нь өөр байвал хэлэлцээрийн төрөл нь мөн өөр байж болох юм. Иймээс талууд нь тухайн нэг урьдчилсан гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох өөр өөр үйл ажиллагааг эрхлэн явуулах тохиолдолд хамтын үйл ажиллагаа болон хамтарсан үйлдвэр зэрэгцэн оршиж болно.**
22. **Баримт материал болон нөхцөл байдал өөрчлөгдсөн бол байгууллага нь өөрийн оролцсон хамтын хэлэлцээрийн төрөл өөрчлөгдсөн эсэхийг дахин үнэлнэ.**

**Хамтын хэлэлцээрийн оролцогч талуудын санхүүгийн тайлан (МЗУ33-МЗУ37-р параграфыг үзнэ үү)**

**Хамтын үйл ажиллагаа**

23. **Хамтын үйл ажиллагаа эрхлэгч нь хамтын үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцоотой холбоотойгоор дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:**
  - (a) **Хөрөнгө, үүн дотроо, хамтран эзэмшиж буй аливаа хөрөнгө дэх өөрийн хувь хэсэг;**
  - (б) **Өр төлбөр, үүн дотроо, хамтран хүлээх аливаа өр төлбөр дэх өөрийн хувь хэсэг;**

- (в) Хамтын үйл ажиллагаанаас үүссэн гарц, бүтээгдэхүүн дэх өөрийн хувь хэсгийг борлуулснаар олох орлого;
  - (г) Хамтын үйл ажиллагаанаас үүссэн гарц, бүтээгдэхүүний борлуулалтын орлогоос өөрт хамаарах хувь хэсэг; ба
  - (д) Зардал, үүн дотроо, хамтран гаргасан аливаа зардал дахь өөрийн хувь хэсэг;
24. Хамтын үйл ажиллагаа эрхлэгч нь хамтын үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцоотой холбоотой хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг тухайн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардалд хамаарах УСНББОУС-уудын дагуу тайлагнана.
- 24А. Байгууллага нь хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшсэн бөгөөд тэрхүү хамтын үйл ажиллагаа нь УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-д тодорхойлсон, үйл ажиллагааг бүрдүүлэх үйл ажиллагаа байх тохиолдолд 23-р параграфт дурдсанчлан, өөрийн хувь оролцоонд хамаарах хэмжээгээр тухайн байгууллага нь энэ Стандарт дахь заавар удирдамжтай үл зөрчилдөх, УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-д заасан худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн бүх зарчмуудыг даган мөрдөх бөгөөд худалдан авалттай холбоотойгоор тэдгээр УСНББОУС-уудад шаардсан мэдээллийг тодруулна. Хамтын үйл ажиллагаагаар эрхлэх үйл ажиллагаа нь үйл ажиллагааг бүрдүүлэх тийм хамтын үйл ажиллагаан дахь анхны болон нэмэлт хувь оролцооны аль алины худалдан авалтанд энэхүү заалт хамаарна. Ийм хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны тайлагналыг МЗУ33А-МЗУ33Г параграфт тусгайлан заасан.
25. Хамтын үйл ажиллагаа эрхлэгч болох хамтын үйл ажиллагаа болон тухайн байгууллагын хооронд хийгдсэн хөрөнгийн борлуулалт, хувь нийлүүлэлт буюу худалдан авалт гэх мэт ажил гүйлгээний тайлагналыг МЗУ34-МЗУ37-р параграфт тусгайлан заасан.
26. Хамтын үйл ажиллагаанд оролцдог боловч хамтын хяналтгүй тал нь тухайн хамтын үйл ажиллагаатай холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй бол тэрхүү хэлэлцээр дэх өөрийн хувь оролцоог мөн 23-25-р параграфын дагуу тайлагнана. Хамтын үйл ажиллагаанд оролцдог боловч хамтын хяналтгүй тал нь тухайн хамтын үйл ажиллагаатай холбоотой хөрөнгийн хувьд эрхгүй, өр төлбөрийн хувьд үүрэггүй бол уг тал нь хамтын үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцоог тэрхүү хувь оролцоонд хамаарах УСНББОУС-уудын дагуу тайлагнана.

#### Хамтарсан үйлдвэр

27. Хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч нь хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь оролцоог хөрөнгө оруулалт гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-д тусгайлан заасанчлан, өмчийн арга хэрэглэхээс чөлөөлөгддөг байхаас бусад тохиолдолд уг Стандартын

дагуу өмчийн арга хэрэглэснээр тухайн хөрөнгө оруулалтаа тайлагнана.

28. Хамтарсан үйлдвэрт оролцдог боловч хамтын хяналтгүй тал нь тухайн хамтарсан үйлдвэрт мэдэгдэхүйц нөлөөтэй байхаас бусад тохиолдолд тэрхүү хэлэлцээр дэх өөрийн хувь оролцоог УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*, УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*, УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга* гэх мэт санхүүгийн хэрэглүүрийг зохицуулдаг УСНББОУС-уудын дагуу тайлагнана, харин мэдэгдэхүйц нөлөөтэй бол хувь оролцоогоо УСНББОУС 36-гийн дагуу тайлагнана.

### Тусдаа санхүүгийн тайлан

29. Хамтын үйл ажиллагаа эрхлэгч эсвэл хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч нь хувь оролцоогоо өөрийн тусдаа санхүүгийн тайланд дараах байдлаар тайлагнана:
- (а) Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог 23-25-р параграфын дагуу; ба
  - (б) Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог УСНББОУС 34-ийн 12-р параграфын дагуу.
30. Хамтын хэлэлцээрт оролцдог боловч хамтын хяналтгүй тал нь хувь оролцоогоо өөрийн тусдаа санхүүгийн тайланд дараах байдлаар тайлагнана:
- (а) Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог 26-р параграфын дагуу; ба
  - (б) Тухайн хамтарсан үйлдвэрт мэдэгдэхүйц нөлөөтэй байхаас бусад тохиолдолд хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь оролцоогоо УСНББОУС 29-ийн дагуу, харин мэдэгдэхүйц нөлөөтэй бол УСНББОУС 34-ийн 12-р параграфын дагуу.

### Шилжилтийн нөхцөл

31. Энэ Стандартыг анх мөрдөх үед, УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны 33-р параграфын шаардлагуудаас үл хамааран байгууллага нь энэхүү Стандартыг мөрдөх анхны тайлант жилийн яг өмнөх тайлант жилийн (“яг өмнөх тайлант үеийн”) хувьд УСНББОУС 3-ын 33(е) параграфээр шаардсан, зөвхөн тоон мэдээллийг толилуулах шаардлагатай байдаг. Байгууллага нь энэ мэдээллийг тухайн тайлант үед эсвэл өмнөх зэрэгцүүлэгдэх тайлант үеүдэд мөн толилуулж болох боловч заавал ингэж толилуулах шаардлагагүй юм.

**Хамтарсан үйлдвэр – Хувь тэнцүүлэн нэгтгэх аргаас өмчийн аргад шилжих**

32. Хувь тэнцүүлэн нэгтгэх аргаас өмчийн аргад шилжих тохиолдолд байгууллага нь тухайн хамтарсан үйлдвэрт оруулсан өөрийн хөрөнгө оруулалтыг тэрхүү шилжилтийн яг өмнөх тайлант үеийн эхэн дэх байдлаар хүлээн зөвшөөрнө. Тухайн байгууллагын хувь тэнцүүлэн өмнө нь нэгтгэсэн хөрөнгө, өр төлбөрийн, үүн дотроо худалдан авалтын ажил гүйлгээнээс үүссэн аливаа гүүдвилийн дансны үнийн нийт дүнгээр уг анхны хөрөнгө оруулалтыг хэмждэг. Хэрэв гүүдвил нь мөнгө бий болгогч арай том нэгж буюу нэгжүүдийн бүлэгт өмнө нь хамаарч байсан бол байгууллага нь тэрхүү гүүдвил харъяалагдаж байсан мөнгө бий болгогч нэгж буюу нэгжүүдийн бүлэг болон тухайн хамтарсан үйлдвэрийн тус тусын харгалзах дансны үнэд үндэслэн уг гүүдвилийг хамтарсан үйлдвэрт хуваарилна.
33. 32-р параграфын дагуу тодорхойлсон, хөрөнгө оруулалтын эхний үлдэгдлийг уг хөрөнгө оруулалтын анх хүлээн зөвшөөрөх үеийн төсөөлөн тооцсон өртөг гэж үзнэ. Байгууллага нь хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан эсэхийг үнэлэхийн тулд тухайн хөрөнгө оруулалтын эхний үлдэгдлийн хувьд УСНББОУС 36-гийн 43-48-р параграфыг мөрдөх бөгөөд аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэн дэх хуримтлагдсан ашиг, алдагдлын залруулга байдлаар хүлээн зөвшөөрнө.
34. Өмнө нь хувь тэнцүүлэн нэгтгэж байсан бүх хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэн нийлүүлснээр сөрөг дүнтэй цэвэр хөрөнгө үүссэн бол байгууллага нь тэрхүү сөрөг дүнтэй цэвэр хөрөнгөтэй холбоотойгоор хуулийн эсвэл гэрээний бус үүрэг хүлээх эсэхийг үнэлнэ, хэрэв ингэж хүлээхээр бол харгалзах өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь уг сөрөг дүнтэй цэвэр хөрөнгөтэй холбоотойгоор хуулийн эсвэл гэрээний бус үүрэг хүлээхгүй гэж дүгнэсэн бол харгалзах өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй боловч тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэн дэх хуримтлагдсан ашиг, алдагдлыг залруулна. Байгууллага нь тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэнд болон энэ Стандартыг анх мөрдсөн өдрөөрх тухайн хамтарсан үйлдвэрийн хүлээн зөвшөөрөөгүй, хуримтлагдсан, өөрт хамаарах гарзын дүнгийн хамтаар энэ тухай тодруулга хийнэ.
35. Байгууллага нь хөрөнгө оруулалтын үлдэгдэл гэсэн нэг мөрийн зүйлд нэгтгэн нийлүүлсэн хөрөнгө, өр төлбөрийн задаргааг тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэн дэх байдлаар харуулж, тодруулна. Байгууллага нь 32-36-р параграфт заасан, шилжилтийн шаардлагуудыг мөрддөг бүх хамтарсан үйлдвэрүүдийн хувьд уг тодруулгыг нэгтгэсэн байдлаар бэлтгэнэ.
36. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, байгууллага нь хамтарсан үйлдвэр дэх өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 36-гийн дагуу өмчийн арга ашиглан тайлагнана.

**Хамтын үйл ажиллагаа – Өмчийн аргаас хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах аргад шилжих**

37. **Хамтын үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцоотой холбоотойгоор өмчийн аргаас хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах аргад шилжсэн тохиолдолд байгууллага нь өмчийн арга ашиглан өмнө нь тайлагнаж байсан хөрөнгө оруулалт, түүнчлэн уг хэлэлцээр дэх тухайн байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлэх аливаа бусад зүйлсийг тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэнд УСНББОУС 36-гийн 41-р параграфын дагуу үл хүлээн зөвшөөрөх бөгөөд хамтын үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцоонд хамаарах хөрөнгө, өр төлбөр тус бүрийн, үүн дотроо тухайн хөрөнгө оруулалтын дансны үнийн нэг хэсгийг бүрдүүлж болох аливаа гүүдвилийн өөрт ногдох хэсгийг хүлээн зөвшөөрнө.**
38. **Хамтын үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө, өр төлбөр дэх өөрийн хувь оролцоог байгууллага нь уг заавал биелүүлэх хэлцлийн дагуу тохиролцсон хувь хэмжээгээр эдлэх эрх ба хүлээх үүрэгтээ үндэслэн тодорхойлно. Өмчийн аргыг мөрдөх үедээ ашигласан мэдээлэлдээ үндэслэн, тухайн байгууллага нь тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэн дэх хөрөнгө оруулалтын дансны үнээс салган зааглах замаар тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн анхны дансны үнийг хэмжинэ.**
39. **УСНББОУС 36-гийн 41-р параграфын дагуу тухайн хэлэлцээр дэх байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлэх аливаа бусад зүйлсийн хамтаар, өмнө нь өмчийн арга ашиглан тайлагнадаг байсан хөрөнгө оруулалт ба уг хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн, үүн дотроо, аливаа гүүдвилийн цэвэр дүн хоорондох аливаа зөрүүг:**
- (a) **Хэрэв хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн, үүн дотроо аливаа гүүдвилийн цэвэр дүн нь үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалтаас (болон байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлэх аливаа бусад зүйлсээс) их байвал тухайн хөрөнгө оруулалтанд хамаарах аливаа гүүдвилээс хасах бөгөөд аливаа үлдсэн дүнг тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэн дэх хуримтлагдсан ашиг, алдагдалд залруулна.**
  - (б) **Хэрэв хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн, үүн дотроо аливаа гүүдвилийн цэвэр дүн нь үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалтаас (болон байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлэх аливаа бусад зүйлсээс) бага байвал тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэн дэх хуримтлагдсан ашиг, алдагдалд залруулна.**
40. **Өмчийн аргаас хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах аргад шилжиж буй байгууллага нь үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалт ба хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн хоорондох тохируулгын тайланг, тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэнд хуримтлагдсан ашиг, алдагдалд залруулсан аливаа үлдэх зөрүүгийн хамт харуулна.**



**Байгууллагын тусдаа санхүүгийн тайлан дахь шилжилтийн нөхцлүүд**

41. **Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоогоо өөрийн тусдаа санхүүгийн тайланд өмнө нь УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан*-гийн 58-р параграфын дагуу өмчийн арга ашиглан эсвэл УСНББОУС 29-ийн дагуу өртгөөр хөрөнгө оруулалт гэж тайлагнадаг байсан байгууллага нь:**
- (а) **Тухайн хөрөнгө оруулалтыг үл хүлээн зөвшөөрч, хамтын үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцоотой холбоотой хөрөнгө, өр төлбөрийг 37-39-р параграфын дагуу тодорхойлсон дүнгээр хүлээн зөвшөөрнө.**
  - (б) **Үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө оруулалт ба хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн хоорондох тохируулгын тайланг, тэрхүү яг өмнөх тайлант үеийн эхэнд хуримтлагдсан ашиг, алдагдалд залруулсан аливаа үлдэх зөрүүгийн хамт харуулна.**

**Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын тайлагнал**

- 41А. 2017 оны 01 дүгээр сард гаргасан, УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 24А, 42Б, МЗУ33А-МЗУ33Г параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь УСНББОУС 40-д тодорхойлсон, үйл ажиллагааг бүрдүүлэх үйл ажиллагаа бүхий хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалт, түүнчлэн эдгээр нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн анхны тайлант үеийн эхлэлээс хойш гарч тохиолдсон ийм худалдан авалтын хувьд эдгээр нэмэлт өөрчлөлтийг гүйцээх горимоор мөрдөнө. Иймээс өмнөх тайлант үеүдэд гарч тохиолдсон, хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын хувьд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг залруулахгүй.

**Хүчин төгөлдөр болох хугацаа**

42. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 34, УСНББОУС 35, УСНББОУС 36, УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-ыг мөрдөнө.**
- 42А. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 6, 6-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 42Б. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 24А, 41А, МЗУ33А-МЗУ33Г параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
- 42В. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 32-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
43. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

### **УСНББОУС 8 (2006 оны 12 дугаар сар)-аас татгалзах ба орлуулах**

44. Энэ Стандарт нь УСНББОУС 8, *Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо* (2006 оны 12 дугаар сар)-ыг орлоно. УСНББОУС 37-г мөрдөх эсвэл энэ Стандарт хүчин төгөлдөр болох хугацааны аль түрүүнд болох өдөр хүртэл УСНББОУС 8 нь мөрдөгдсөн хэвээр байна.

## Хавсралт А

### Мөрдөх заавар удирдамж

*Энэ Хавсралт нь УСНББОУС 37-гийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

МЗУ1. Энэ Хавсралт дахь жишээнүүд нь таамагласан нөхцөл байдлуудыг илэрхийлнэ. Хэдийгээр эдгээр жишээний зарим төлөв байдал нь бодит нөхцөл байдалд илрэн гарч болох боловч УСНББОУС 37-г мөрдөх үедээ тухайн тодорхой хэв загварын бүх баримт материал болон нөхцөл байдлыг үнэлэх шаардлагатай байдаг.

### Хамтын хэлэлцээр

#### Заавал биелүүлэх хэлцэл (8-р параграф)

МЗУ2. Энэ Стандартад дурдсан, заавал биелүүлэх хэлцлийн тодорхойлолттой нийцсэн, заавал биелүүлэх хэлцлийн талаархи энэхүү хэлэлцүүлэг нь хууль тогтоох эсвэл засаглах бүрэн эрхээр бий болгох, хүчин төгөлдөр хэрэгжих хэлцлүүдэд бас хамааралтай байна.

МЗУ3. Хамтын хэлэлцээрийг тусдаа бүтцээр дамжуулан зохион байгуулсан тохиолдолд (МЗУ19-МЗУ33-р параграфыг үзнэ үү) тухайн заавал биелүүлэх хэлцэл буюу заавал биелүүлэх хэлцлийн зарим төлөв байдал нь уг тусдаа бүтцийн дүрэм, үүсгэн байгуулах гэрээнд зарим үед тусгагдсан байдаг.

МЗУ4. Заавал биелүүлэх хэлцэл нь уг хэлэлцээрийн зүйл болох үйл ажиллагаанд тэдгээр талууд оролцох нөхцлийг тодорхойлон заадаг. Заавал биелүүлэх хэлцэл нь ерөнхийдөө дараах гэх мэт асуудлуудыг зохицуулдаг:

- (а) Хамтын хэлэлцээрийн зорилго, үйл ажиллагаа, үргэлжлэх хугацаа.
- (б) Хамтын хэлэлцээрийн захирлуудын зөвлөл буюу адилтгах эрх бүхий байгууллагын гишүүдийг хэрхэн сонгож, томилгох.
- (в) Шийдвэр гаргах үйл явц: талуудын шийдвэрийг шаардах асуудлууд, тэдгээр асуудлуудын талаархи талуудын саналын эрх болон дэмжлэгийн шаардлагатай түвшин. Заавал биелүүлэх хэлцэлд тусгагдсан шийдвэр гаргах үйл явц нь уг хэлэлцээрийн хамтын хяналтыг тогтоодог (МЗУ5-МЗУ11-р параграфыг үзнэ үү).
- (г) Талуудын шаардлагатай капиталын буюу бусад хувь нийлүүлэлт.
- (д) Хамтын хэлэлцээртэй холбоотой хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал, ашиг, алдагдлыг талууд хэрхэн хуваалцах.

#### Хамтын хяналт (12-18-р параграф)

МЗУ5. Байгууллага нь хэлэлцээрт хамтын хяналттай эсэхийг тогтоохдоо, бүх талууд буюу талуудын бүлэг нь уг хэлэлцээрийг хянадаг эсэхийг тухайн байгууллага эхлээд үнэлнэ. Бүх талууд буюу талуудын бүлэг нь тухайн хэлэлцээр дэх өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй бөгөөд уг хэлэлцээр дэх өөрийн бүрэн эрхээрээ дамжуулан тэдгээр өгөөжид нөлөө үзүүлэх чадвар, боломжтой эсэхийг тодорхойлохын тулд хяналтыг ашиглах хэрэгтэй гэдгийг, түүнчлэн хяналтыг УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-д тодорхойлсон байдаг. Хамтад нь авч үзсэн, бүх талууд буюу талуудын бүлэг нь уг хэлэлцээрийн (өөрөөр хэлбэл, холбогдох үйл ажиллагааны) өгөөжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвар, боломжтой тохиолдолд талууд нь уг хэлэлцээрийг хамтран хянадаг.

- МЗУ6. Бүх талууд буюу талуудын бүлэг нь хэлэлцээрийг хамтран хянадаг гэж дүгнэсний дараа, байгууллага нь уг хэлэлцээрт хамтын хяналттай эсэхээ үнэлнэ. Холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэр нь тухайн хэлэлцээрийг хамтран хянадаг талуудын санал нэгтэй зөвшөөрлийг шаарддаг зөвхөн тийм тохиолдолд хамтын хяналт оршин байдаг. Хэлэлцээрийг түүнд оролцогч бүх талууд буюу талуудын бүлэг хамтран хянадаг, эсвэл талуудын зөвхөн нэг нь хянадаг эсэхийг үнэлэхдээ шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг.
- МЗУ7. Заавал биелүүлэх хэлцлээр талуудын тохиролцсон шийдвэр гаргах үйл явц нь зарим үед хамтын хяналтанд шууд бусаар хүргэдэг. Жишээлбэл; хоёр тал нь хэлэлцээр хийсэн бөгөөд тал тус бүр 50 хувийн саналын эрхтэй, холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахын тулд наад зах нь саналын эрхийн 51 хувь шаардлагатай гэж уг хэлэлцээрт тусгайлан заасан гэж үзье. Энэ тохиолдолд хоёр талын аль аль нь зөвшөөрөхгүйгээр холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргаж чадахгүй учраас тэдгээр талууд нь уг хэлэлцээрт хамтын хяналттай байхыг шууд бусаар хүлээн зөвшөөрсөн гэсэн үг юм.
- МЗУ8. Өөр бусад тохиолдолд, заавал биелүүлэх хэлцэл нь холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах саналын эрхийн хамгийн бага хэмжээг заасан байж болно. Хамтран зөвшөөрсөн талуудын нэгээс олон нэгдэлт нь саналын эрхийн уг шаардлагатай хамгийн бага хувь хэмжээнд хүрэхээр бол хэлэлцээрийн холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэрийн хувьд аль тал (буюу талуудын нэгдэл) нь санал нэгтгэйгээр зөвшөөрөх шаардлагатай гэдгийг тухайн заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан зааснаас бусад тохиолдолд тэрхүү хэлэлцээр нь хамтын хэлэлцээр болохгүй юм.

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

### Мөрдөх жишээ

#### Жишээ 1

Гурван тал нь хэлэлцээр байгуулсан бөгөөд уг хэлэлцээрт А тал нь 50 хувийн, Б тал нь 30 хувийн, В тал нь 20 хувийн саналын эрхтэй гэж үзье. А, Б, В талуудын хоорондох заавал биелүүлэх хэлцэл нь уг хэлэлцээрийн холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахын тулд наад зах нь саналын эрхийн 75 хувь шаардлагатай гэж тусгайлан заасан. Хэдийгээр А тал нь аливаа шийдвэр гаргахыг хориглож чадах боловч Б талтай зөвшилцөхгүйгээр уг хэлэлцээрийг хянаж чадахгүй. А ба Б талууд нь зөвшөөрөхгүйгээр уг хэлэлцээрийн холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргаж чадахгүй учраас тэдгээр холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахын тулд наад зах нь саналын эрхийн 75 хувь шаардлагатай гэсэн энэхүү заавал биелүүлэх хэлцлийн нөхцөл нь А ба Б талууд энэхүү хэлэлцээрт хамтын хяналттай гэсэн утгыг илэрхийлнэ.

#### Жишээ 2

Гурван тал нь хэлэлцээр байгуулсан бөгөөд уг хэлэлцээрт А тал нь 50 хувийн, Б ба В тал нь тус бүр 25 хувийн саналын эрхтэй гэж үзье. А, Б, В талуудын хоорондох заавал биелүүлэх хэлцэл нь уг хэлэлцээрийн холбогдох үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахын тулд наад зах нь саналын эрхийн 75 хувь шаардлагатай гэж тусгайлан заасан. Хэдийгээр А тал нь аливаа шийдвэр гаргахыг хориглож чадах боловч Б эсвэл В талын аль нэгтэй зөвшилцөхгүйгээр уг хэлэлцээрийг хянаж чадахгүй. Энэ жишээнд А, Б, В талууд нь уг хэлэлцээрийг хамтран хянана. Гэхдээ саналын эрхийн 75 хувьд хүрэхийн тулд зөвшилцөх шаардлагатай талуудын нэгээс олон нэгдэл (өөрөөр хэлбэл, А ба Б, эсвэл А ба В) байна. Ийм тохиолдолд хамтын хэлэлцээр болохын тулд уг хэлэлцээрийн холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэрийг талуудын аль нэг нэгдэл нь санал нэгтэй зөвшөөрөх ёстой гэдгийг тэдгээр талуудын хоорондох заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заах шаардлагатай.


#### Жишээ 3

Хэлэлцээрт А ба Б талууд нь тус бүр 35 хувийн саналын эрхтэй бөгөөд үлдэх 30 хувийн саналын эрх нь өргөн тархсан гэж үзье. Холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэр нь саналын эрхийн олонхийн зөвшөөрлийг шаарддаг. Хэлэлцээрийн холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэр нь А ба Б тал хоёулаа зөвшилцөлд хүрэхийг шаардана гэж уг заавал биелүүлэх хэлцэлд зөвхөн заасан тохиолдолд А ба Б тал нь хэлэлцээрт хамтын хяналттай байна.

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

- МЗУ9. Санал нэгтэй зөвшөөрлийн шаардлага гэдэг нь уг хэлэлцээрт хамтын хяналт бүхий аль нэг тал нь бусад талууд буюу талуудын бүлгийн аль нэгний зөвшөөрөлгүйгээр (тэрхүү холбогдох үйл ажиллагааны талаар) дангаараа шийдвэр гаргахаас сэргийлнэ гэсэн үг юм. Хэрэв санал нэгтэй зөвшөөрлийн шаардлага нь уг хэлэлцээрийн холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэртэй биш, харин аль нэг талд хамгаалалтын эрх олгох шийдвэртэй зөвхөн холбоотой бол тэрхүү тал нь тухайн хэлэлцээрт хамтын хяналт бүхий тал биш юм.
- МЗУ10. Заавал биелүүлэх хэлцэл нь маргааныг шийдвэрлэх, тухайлбал арбитраар шийдвэрлүүлэх талаархи заалтыг тусгасан байж болно. Эдгээр заалтууд нь хамтын хяналт бүхий талуудын хооронд санал нэгтэй зөвшилцөлд хүрээгүй үед шийдвэр гаргах боломж олгодог. Ийм заалтуудтай байх нь уг хэлэлцээрийг хамтран хянах, ингэснээр хамтын хэлэлцээр болоход саад учруулахгүй.

### Хамтын хяналтыг үнэлэх



- МЗУ11. Хэлэлцээр нь УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-ийн цар хүрээнд хамаарахгүй бол байгууллага нь уг хэлэлцээр дэх өөрийн хувь оролцоог УСНББОУС 35, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*, УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт* гэх мэт холбогдох УСНББОУС-уудын дагуу тайлагнана.

### **Хамтын хэлэлцээрийн төрлүүд (9-22-р параграф)**

- МЗУ12. Хамтын хэлэлцээрийг янз бүрийн зорилгоор (жишээлбэл; өртөг зардал болон эрсдлийг талууд хуваалцах арга замаар, эсвэл шинэ технологи болон шинэ зах зээлд хандан нэвтрэх боломжийг талуудад олгох арга замаар), түүнчлэн өөр өөр бүтэц ба хуулийн хэлбэр ашигласнаар байгуулдаг.
- МЗУ13. Зарим хэлэлцээр нь тусдаа бүтцээр хийгдэх хэлэлцээрийн зүйл болох тийм үйл ажиллагааг шаарддаггүй. Гэвч өөр бусад хэлэлцээр нь тусдаа бүтэц үүсгэлтийг агуулсан байдаг.
- МЗУ14. Энэ Стандартаар шаардсан хамтын хэлэлцээрийн ангилал нь хэвийн үйл ажиллагааны явцад тухайн хэлэлцээрээс үүсэх, тэдгээр талуудын эрх ба үүргээс хамаардаг. Энэхүү Стандарт нь хамтын хэлэлцээрийг хамтын үйл ажиллагаа эсвэл хамтарсан үйлдвэр гэж ангилдаг. Байгууллага нь уг хэлэлцээртэй холбоотойгоор хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй тохиолдолд тухайн хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа байна. Байгууллага нь хэлэлцээрийн цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй тохиолдолд уг хэлэлцээр нь хамтарсан үйлдвэр байна. Байгууллага нь хамтын үйл ажиллагаа эсвэл хамтарсан үйлдвэрт хувь оролцоотой эсэхийг тодорхойлохын тулд гүйцэтгэх үнэлгээг МЗУ16-МЗУ33-р параграфт заасан.

### **Хамтын хэлэлцээрийн ангилал**

- МЗУ15. МЗУ14-р параграфт заасанчлан, хамтын хэлэлцээрийн ангилал нь уг хэлэлцээрээс үүсэх өөрийн эрх ба үүргээ үнэлэхийг талуудаас шаарддаг. Уг үнэлгээг хийхдээ байгууллага нь дараах зүйлсийг харгалзан үзнэ:
- (a) Хамтын хэлэлцээрийн бүтэц (МЗУ16-МЗУ21-р параграфыг үзнэ үү).
  - (б) Тухайн хамтын хэлэлцээрийг тусдаа бүтцээр дамжуулан зохион байгуулдаг тохиолдолд:
    - (i) Уг тусдаа бүцтийн хуулийн хэлбэр (МЗУ22-МЗУ24-р параграфыг үзнэ үү);
    - (ii) Заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүд (МЗУ25-МЗУ28-р параграфыг үзнэ үү); ба
    - (iii) Хамааралтай тохиолдолд бусад баримт материал ба нөхцөл байдал (МЗУ29-МЗУ33-р параграфыг үзнэ үү).

### **Хамтын хэлэлцээрийн бүтэц, зохион байгуулалт**

*Тусдаа бүтцээр дамжуулан зохион байгуулдаггүй хамтын хэлэлцээр*

- МЗУ16. Тусдаа бүтцээр дамжуулан зохион байгуулдаггүй хамтын хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа юм. Ийм тохиолдолд, хэлэлцээртэй холбоотой талуудын хөрөнгийн эрх ба өр төлбөрийн үүрэг, түүнчлэн талуудын

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

холбогдох орлогын эрх ба харгалзах зардлын үүргийг тухайн заавал биелүүлэх хэлцлээр тогтоодог.

- МЗУ17. Заавал биелүүлэх хэлцэл нь уг хэлэлцээрийн зүйл болох үйл ажиллагааны шинж төрөл, түүнчлэн тэдгээр үйл ажиллагааг талууд хэрхэн гүйцэтгэхээр төлөвлөж байгааг ихэвчлэн тодорхойлдог. Жишээлбэл; хамтын хэлэлцээрийн оролцогч талууд нь хамтран үйлчилгээ үзүүлэх буюу бүтээгдэхүүн үйлдвэрлэх бөгөөд тал тус бүр тусгайлан заасан үүрэг даалгаврыг хариуцах, өөрсдийн хөрөнгийг ашиглах ба өр төлбөрийг хариуцахаар тохиролцож болно. Мөн талуудын аль алинд нь нийтлэг хамаарах орлого, зардлыг тэдгээр талуудад хэрхэн хуваан хуваарилахыг уг заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан зааж болно. Ийм тохиолдолд хамтын үйл ажиллагаа эрхлэгч бүр нь уг тусгай үүрэг даалгаварт ашигласан хөрөнгө ба өр төлбөр, түүнчлэн өөрт хамаарах орлого, зардлын хувь хэсгийг тухайн заавал биелүүлэх хэлцлийн дагуу тус тусын санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрнө.
- МЗУ18. Өөр зарим тохиолдолд, хамтын хэлэлцээрийн оролцогч талууд нь тухайлбал, хөрөнгөө хамтран ашиглах ба хамтран ажиллуулахаар тохиролцож болох юм. Ийм тохиолдолд, тухайн хамтран ажиллуулах хөрөнгөтэй холбоотой талуудын эрх, тэрхүү хөрөнгөөс бий болох гарц буюу орлого, түүнчлэн үйл ажиллагааны зардлыг тэдгээр талуудад хэрхэн хуваан хуваарилахыг уг заавал биелүүлэх хэлцэлд заадаг. Хамтын үйл ажиллагаа эрхлэгч бүр нь уг хамтын хөрөнгө дэх өөрийн хувь хэсэг, аливаа өр төлбөрийн хувьд хариуцахаар тохиролцсон хувь хэсгийг тайлагнаж, гарц бүтээгдэхүүн, орлого, зардал дахь өөрийн хувь хэсгийг тухайн заавал биелүүлэх хэлцлийн дагуу хүлээн зөвшөөрнө.

### *Тусдаа бүтцээр дамжуулан зохион байгуулдаг хамтын хэлэлцээр*


- МЗУ19. Тухайн хэлэлцээртэй холбоотой хөрөнгө, өр төлбөрийг тусдаа бүтцэд эзэмшүүлдэг хамтын хэлэлцээр нь хамтарсан үйлдвэр эсвэл хамтын үйл ажиллагаа байж болно.
- МЗУ20. Оролцогч тал нь хамтын үйл ажиллагаа эрхлэгч эсвэл хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч эсэх нь тухайн тусдаа бүтцэд эзэмшүүлсэн, уг хэлэлцээртэй холбоотой хөрөнгө дэх тэрхүү талын эрх болон өр төлбөрийн хувьд түүний хүлээх үүргээс хамаардаг.
- МЗУ21. МЗУ15-р параграфт заасанчлан, талууд нь хамтын хэлэлцээрийг тусдаа бүтцээр дамжуулан зохион байгуулдаг бол уг тусдаа бүтцийн хуулийн хэлбэр, заавал биелүүлэх хэлцлийн нөхцөл, түүнчлэн хамааралтай бусад аливаа баримт материал болон нөхцөл байдлууд нь тэдгээр талуудад дараах зүйлсийг үүсгэн бий болгодог эсэхийг талууд үнэлэх шаардлагатай:
- (а) Тухайн хэлэлцээртэй холбоотойгоор хөрөнгийн хувьд эрх ба өр төлбөрийн хувьд үүрэг (өөрөөр хэлбэл, хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа байх); эсвэл



## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

- (б) Тухайн хэлэлцээрийн цэвэр хөрөнгийн хувьд эрх (өөрөөр хэлбэл, хэлэлцээр нь хамтарсан үйлдвэр байх).

### Хамтын хэлэлцээрийн ангилал: уг хэлэлцээрээс үүссэн талуудын эрх ба үүргийн үнэлгээ



### Тусдаа бүтцийн хуулийн хэлбэр

- МЗУ22. Хамтын хэлэлцээрийн төрлийг үнэлэх үед уг тусдаа бүтцийн хуулийн хэлбэр нь хамааралтай байдаг. Тухайн тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгөн дэх талуудын эрх ба өр төлбөрийн хувьд хүлээх үүргийн талаар анхны үнэлгээг хийхэд уг бүтцийн хуулийн хэлбэр ач холбогдолтой байдаг. Тухайлбал; талууд нь уг тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгөнд хувь оролцоотой ба тэрхүү тусдаа бүтцэд хамаарах өр төлбөрийн хувьд үүрэг хүлээх эсэх.
- МЗУ23. Жишээлбэл; тусдаа бүтцийн хуулийн хэлбэр нь түүнийг бие даасан байдлаар авч үзэхэд хүргэдэг (өөрөөр хэлбэл, тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь тэдгээр талуудын хөрөнгө, өр төлбөр биш, харин уг тусдаа бүтцийн хөрөнгө, өр төлбөр байх) тийм тусдаа бүтцээр дамжуулан талууд нь хамтын хэлэлцээрийг хийж болно. Ийм тохиолдолд уг тусдаа бүтцийн хуулийн хэлбэрээр талуудад олгох эрх ба хүлээлгэх үүргийн үнэлгээ нь тухайн хэлэлцээр хамтарсан үйлдвэр гэдгийг илэрхийлнэ. Гэвч заавал биелүүлэх хэлцлээр талуудын тохиролцсон нөхцлүүд (МЗУ25-МЗУ28-р параграфыг үзнэ үү) болон хамааралтай тохиолдолд бусад баримт материал ба нөхцөл байдал (МЗУ29-МЗУ33-р параграфыг үзнэ үү) нь уг тусдаа бүтцийн хуулийн

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

хэлбэрээр талуудад олгосон эрх ба хүлээлгэсэн үүргийг хэрэгсэхгүй байж болох юм.

МЗУ24. Тусдаа бүтцийн хуулийн хэлбэр нь тэдгээр талууд болон уг тусдаа бүтцийн хооронд зааг тусгаарлалт үүсгэдэггүй (өөрөөр хэлбэл, тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь тэдгээр талуудын хөрөнгө, өр төлбөр байх) тийм тусдаа бүтцээр дамжуулан талууд нь хамтын хэлэлцээрийг хийдэг зөвхөн тэр тохиолдолд тусдаа бүтцийн хуулийн хэлбэрээр талуудад олгосон эрх ба хүлээлгэсэн үүргийн үнэлгээ нь тухайн хэлэлцээр хамтын үйл ажиллагаа гэж дүгнэхэд хангалттай байдаг.

### Заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүдийг үнэлэх

МЗУ25. Олон тохиолдолд заавал биелүүлэх хэлцлээр талуудын тохиролцсон эрх, үүрэг нь уг хэлэлцээрийг зохион байгуулсан тухайн тусдаа бүтцийн хуулийн хэлбэрээр талуудад олгосон эрх ба хүлээлгэсэн үүрэгтэй нийцдэг буюу зөрчилддөггүй.

МЗУ26. Өөр зарим тохиолдолд, талууд нь уг хэлэлцээрийг зохион байгуулсан тухайн тусдаа бүтцийн хуулийн хэлбэрээр талуудад олгосон эрх ба хүлээлгэсэн үүргийг буцаах буюу засварлан өөрчлөхийн тулд заавал биелүүлэх хэлцлийг ашигладаг.

#### Мөрдөх жишээ

##### Жишээ 4

Хоёр тал нь хувь нийлүүлсэн байгууллага үүсгэх замаар хамтын хэлэлцээрийг зохион байгуулсан гэж үзье. Уг хувь нийлүүлсэн байгууллагад тал тус бүр нь 50 хувийн өмчлөлийн оролцоотой. Хувь нийлүүлсэн байгууллага нь тухайн байгууллагыгтүүний эздээс зааглан тусгаарлах боломж олгодог, ингэснэр тэрхүү байгууллагад эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь уг хувь нийлүүлсэн байгууллагын хөрөнгө, өр төлбөр болно. Ийм тохиолдолд, тухайн тусдаа бүтцийн хуулийн хэлбэрээр талуудад олгосон эрх ба хүлээлгэсэн үүргийн үнэлгээ нь тэдгээр талууд уг хэлэлцээрийн цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй гэдгийг илэрхийлнэ.

Гэвч тусгайлан тохиролцсон хувь хэмжээгээр, тал тус бүр нь уг хувь нийлүүлсэн байгууллагын хөрөнгөнд оролцоотой байх ба өр төлбөрийн хувьд үүрэг хариуцлага хүлээхийн тулд тэдгээр талууд нь заавал биелүүлэх хэлцлээр дамжуулан тухайн хувь нийлүүлсэн байгууллагын шинжийг засварлан өөрчилж болно. Хувь нийлүүлсэн байгууллагын шинжид оруулах ийм заавал биелүүлэх засвар өөрчлөлт нь тухайн хэлэлцээрийг хамтын үйл ажиллагаа болгох үр дүнтэй байж болно.

МЗУ27. Хамтын үйл ажиллагааны оролцогч талуудын заавал биелүүлэх хэлцлийн нийтлэг нөхцлүүд ба хамтарсан үйлдвэрийн оролцогч талуудын заавал биелүүлэх хэлцлийн нийтлэг нөхцлүүдийг харьцуулж, дараах хүснэгтэнд харуулсан. Дараах хүснэгтэнд тусгасан заавал

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Биелүүлэх хэлцлийн нөхцлүүдийн уг жишээнд бүгдийг багтаагаагүй болно.

<b>Заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүдийг үнэлэх</b>		
	<b>Хамтын үйл ажиллагаа</b>	<b>Хамтарсан үйлдвэр</b>
<b>Заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүд</b>	Заавал биелүүлэх хэлцэл нь хамтын хэлэлцээрийн оролцогч талуудад уг хэлэлцээртэй холбоотойгоор хөрөнгийн хувьд эрх олгодог ба өр төлбөрийн хувьд үүрэг хүлээлгэдэг.	Заавал биелүүлэх хэлцэл нь хамтын хэлэлцээрийн оролцогч талуудад уг хэлэлцээрийн цэвэр хөрөнгийн хувьд эрх олгодог (өөрөөр хэлбэл, тэдгээр талууд биш, харин тусдаа бүтэц нь уг хэлэлцээртэй холбоотойгоор хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй байдаг).
<b>Хөрөнгийн эрх</b>	Хамтын хэлэлцээрийн талууд нь уг хэлэлцээртэй холбоотойгоор тухайн хөрөнгүүд дэх бүх хувь оролцоог (эрх, хөрөнгийн эрх буюу өмчлөлийг) тохиролцсон хувь хэмжээгээр (жишээлбэл; хэлэлцээр дэх талуудын өмчлөлийн хувь оролцоотой хувь тэнцүүлэн эсвэл уг хэлэлцээрийн дагуу гүйцэтгэсэн ба тэдгээр талуудад шууд хамаарах үйл ажиллагаатай хувь тэнцүүлэн) хуваан хуваарилахаар заавал биелүүлэх хэлцэлд заасан байдаг.	Тухайн хэлэлцээрт оруулсан эсвэл хамтын хэлэлцээрээр дараа олж эзэмшсэн хөрөнгүүд нь уг хэлэлцээрийн хөрөнгө байхаар заавал биелүүлэх хэлцэлд заадаг. Талууд нь уг хэлэлцээрийн хөрөнгөнд хувь оролцоогүй (өөрөөр хэлбэл, эрх, хөрөнгийн эрх буюу өмчлөлгүй) байдаг.
<b>Өр төлбөрийн үүрэг</b>	Хамтын хэлэлцээрийн талууд нь бүх өр төлбөр, үүрэг, өртөг, зардлыг тохиролцсон хувь хэмжээгээр (жишээлбэл; хэлэлцээр дэх талуудын өмчлөлийн хувь оролцоотой хувь тэнцүүлэн эсвэл уг хэлэлцээрийн дагуу гүйцэтгэсэн ба тэдгээр талуудад шууд хамаарах үйл ажиллагаатай хувь тэнцүүлэн) хуваан хуваарилахаар заавал биелүүлэх хэлцэлд заасан байдаг.	Хамтын хэлэлцээр нь уг хэлэлцээрийн өр төлбөр болон үүргийн хувьд хариуцлага хүлээхээр заавал биелүүлэх хэлцэлд заасан байдаг.  Хамтын хэлэлцээрийн талууд нь уг хэлэлцээрт оруулсан зөвхөн өөрсдийн харгалзах хөрөнгө оруулалтын хэмжээгээр, эсвэл тухайн хэлэлцээрт оруулах ёстой аливаа төлөгдөөгүй буюу нэмэлт капиталыг, эсвэл эдгээрийн аль алиныг хувь нийлүүлэн өгөх тус тусын харгалзах үүргийн хэмжээгээр тэрхүү хэлэлцээрт хариуцлага хүлээхээр заавал биелүүлэх хэлцэлд заасан байдаг.

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

	Хамтын хэлэлцээрийн талууд нь гуравдагч талуудын гаргасан нэхэмжлэлийг хариуцахаар заавал биелүүлэх хэлцэлд заасан байдаг.	Хамтын хэлэлцээрийн зээлдүүлэгчид нь уг хэлэлцээрийн өр буюу үүргийн хувьд аливаа талаас баталгаа шаардах эрхгүй байхаар заавал биелүүлэх хэлцэлд заасан байдаг.
<b>Орлого ба зардал, олз ба гарз</b>	Хамтын хэлэлцээрийн тал тус бүрийн харгалзах үр дүнд үндэслэн орлого, зардлыг хуваарилахаар заавал биелүүлэх хэлцэлд заасан байдаг. Жишээлбэл; хамтран ажиллуулдаг үйлдвэрт тал тус бүрийн ашиглаж буй хүчин чадалд үндэслэн орлого, зардлыг хуваарилахаар заавал биелүүлэх хэлцэлд зааж болох юм. Тал тус бүрийн ашиглаж буй хүчин чадал нь хамтын хэлэлцээрт заасан тэдгээрийн өмчлөлийн хувь оролцооноос өөр байж болно. Өөр зарим тохиолдолд талууд нь уг хэлэлцээр дэх талуудын өмчлөлийн хувь оролцоо гэх мэт тусгайлан тохиролцсон хувь хэмжээнд үндэслэн тэрхүү хэлэлцээрийн ашиг, алдагдлыг хуваан хуваарилахаар тохиролцсон байж болно. Хэрэв талууд нь тухайн хэлэлцээртэй холбоотойгоор хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй бол дээр дурдсанчлан, тохиролцсон хувь хэмжээгээр хуваарилж буй нь уг хэлэлцээрийг хамтын хэлэлцээр болоход саад учруулахгүй юм.	Уг хэлэлцээрийн үйл ажиллагаатай холбоотой ашиг, алдагдлаас тал тус бүрд хамаарах хувь хэмжээг тухайн заавал биелүүлэх хэлцлээр тогтоодог.
<b>Заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүдийг үнэлэх</b>		
	<b>Хамтын үйл ажиллагаа</b>	<b>Хамтарсан үйлдвэр</b>
<b>Баталгаа</b>	Хамтын хэлэлцээрийн талууд нь уг хамтын хэлэлцээрээс үйлчилгээ авах буюу түүнд санхүүжилт олгох гэх мэт баталгааг ихэвчлэн гуравдагч талд гарган өгөх шаардлагатай байдаг. Хамтын хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа эсэхийг ийм баталгааны нөхцөл буюу тэдэнд гарган өгсөн талуудын баталгаа дангаараа илэрхийлэхгүй. Хамтын хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа эсвэл хамтарсан үйлдвэр гэдгийг тодорхойлох шинж нь хэлэлцээрийн оролцогч талууд уг хэлэлцээртэй холбоотой өр төлбөрийн хувьд үүрэг хүлээдэг эсэх явдал юм (талуудын зарим нь баталгаа гаргадаг эсвэл гаргадаггүй байж болно).	

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

МЗУ28. Талууд нь хэлэлцээртэй холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй эсэхийг заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заасан тохиолдолд тэдгээр нь хамтын үйл ажиллагааны оролцогч талууд болох бөгөөд уг хамтын хэлэлцээрийг ангилах зорилгоор бусад баримт материал болон нөхцөл байдлуудыг (МЗУ29-МЗУ33-р параграфыг үзнэ үү) харгалзан үзэх шаардлагагүй юм.

### **Бусад баримт материал болон нөхцөл байдлуудыг үнэлэх**

МЗУ29. Талууд нь хэлэлцээртэй холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй эсэхийг заавал биелүүлэх хэлцлийн нөхцөлд тусгайлан заагаагүй тохиолдолд уг хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа эсвэл хамтарсан үйлдвэр эсэхийг үнэлэхийн тулд талууд нь бусад баримт материал болон нөхцөл байдлуудыг харгалзан үзнэ.

МЗУ30. Тусдаа бүтцийн хуулийн хэлбэр нь тэдгээр талууд болон уг тусдаа бүтцийн хооронд зааг тусгаарлалт үүсгэдэг тийм тусдаа бүтцээр дамжуулан хамтын хэлэлцээрийг зохион байгуулсан байж болно. Хөрөнгөн дэх талуудын эрх ба өр төлбөрийн хувьд хүлээх үүргийг тэдгээр талуудын хооронд тохиролцсон, заавал биелүүлэх нөхцөлд тусгайлан заагаагүй боловч бусад баримт материал болон нөхцөл байдлуудыг харгалзан үзсэнээр уг хэлэлцээрийг хамтын үйл ажиллагаа гэж ангилж болох юм. Бусад баримт материал болон нөхцөл байдал нь уг хэлэлцээртэй холбоотойгоор талуудад хөрөнгийн эрх олгодог ба өр төлбөрийн хувьд үүрэг хүлээлгэдэг бол ийм нөхцөл үүснэ.

МЗУ31. Хэлэлцээрийн үйл ажиллагаа нь талуудад гарц, бүтээгдэхүүн олгоход юуны өмнө чиглэдэг бол энэ нь уг хэлэлцээрийн бараг бүх хөрөнгийн үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжийг тэдгээр талууд хүртэх эрхтэй гэдгийг илэрхийлнэ. Ийм хэлэлцээрийн оролцогч талууд нь гарц, бүтээгдэхүүнийг гуравдагч талд борлуулахаас уг хэлэлцээрийг сэргийлснээр түүний бий болгох гарц, бүтээгдэхүүнийг ихэвчлэн өөрсдөө авах боломжтой болдог.

МЗУ32. Ийм бүтэц ба зорилго бүхий хэлэлцээрийн үр дүнд, тухайн хэлэлцээрийн өр төлбөрийг мөн чанарын хувьд түүний гарц, бүтээгдэхүүнийг талууд худалдан авснаар тэднээс хүлээн авсан мөнгөн гүйлгээгээр барагдуулна. Талууд нь уг хэлэлцээрийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад хувь нэмрээ оруулж буй мөнгөн гүйлгээний үндсэндээ цорын ганц эх үүсвэр байх тохиолдолд энэ нь тэдгээр оролцогч талууд уг хэлэлцээртэй холбоотой өр төлбөрийн хувьд үүрэг хүлээнэ гэдгийг илэрхийлдэг.

<p><b>Мөрдөх жишээ</b></p>
<p><b>Жишээ 5</b></p> <p>Хоёр тал нь хувь нийлүүлсэн байгууллага (В байгууллага) үүсгэх замаар хамтын хэлэлцээрийг зохион байгуулж, хийсэн гэж үзье. Уг хувь нийлүүлсэн байгууллагад тал тус бүр нь 50 хувийн өмчлөлийн оролцоотой. Энэхүү хэлэлцээрийн зорилго нь талуудын хувийн хэрэгцээнд буюу тус тусын үйлдвэрлэлийн процессод шаардлагатай материалыг үйлдвэрлэх явдал юм. Талууд нь өөрсдийн гаргасан тоо хэмжээний болон чанарын тодорхойлолтын дагуу материалыг үйлдвэрлэхийн тулд уг байгууламжийг ажиллуулдаг гэдгийг энэхүү хэлэлцээрээр ханган магадалдаг.</p> <p>Үйл ажиллагааг анх эрхлэн явуулах В байгууллагын (хувь нийлүүлсэн байгууллагын) хуулийн хэлбэр нь уг В байгууллагад эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр бол түүний хөрөнгө, өр төлбөр гэдгийг илэрхийлдэг. Талуудын хоорондох заавал биелүүлэх хэлцэл нь талууд уг В байгууллагын хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй эсэхийг тусгайлан заадаггүй. Иймээс В байгууллагын хуулийн хэлбэр ба заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүд нь уг хэлэлцээр хамтарсан үйлдвэр болно гэдгийг илэрхийлнэ.</p>
<p>Гэвч талууд нь уг хэлэлцээрийн дараах төлөв байдлуудыг мөн харгалзан үзнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Талууд нь В байгууллагын үйлдвэрлэсэн бүх гарц, бүтээгдэхүүнийг 50:50 хувиар худалдан авахыг зөвшөөрсөн. Уг хэлэлцээрийн оролцогч хоёр тал нь зөвшөөрснөөс бусад тохиолдолд В байгууллага нь өөрийн ямар нэг гарц, бүтээгдэхүүнийг гуравдагч талд борлуулж болохгүй. Хэлэлцээрийн зорилго нь оролцогч талуудыг гарц, бүтээгдэхүүнээр хангах явдал учраас тэдгээр талууд нь гуравдагч талд хийх ийм борлуулалтыг хэвийн бус зүйл гэж үзэх бөгөөд борлуулалт хийлээ гэхэд материаллаг бус дүнтэй байхыг шаардана.</li> <li>• Оролцогч талууд нь тэдгээрт борлуулсан бүтээгдэхүүний үнийг В байгууллагын гаргасан үйлдвэрлэлийн өртөг болон удирдлагын зардлыг нөхөх тийм түвшнээр хамтран тогтоодог. Үйл ажиллагааны ийм загварт үндэслэн уг хэлэлцээрийг тэг ашигтай буюу хугарлын цэгийн түвшнээр ажиллуулах зорилготой байдаг.</li> </ul>
<p>Дээрх бодит байдлын өгөгдлөөс харвал, дараах баримт материал болон нөхцөл байдал нь мөн хамааралтай байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• В байгууллагын үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүнийг худалдан авах уг оролцогч талуудын үүрэг нь мөнгөн гүйлгээ үүсгэн бий болгоход В байгууллага тэдгээр талуудаас бүрэн хамааралтай, иймээс</li> </ul>

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

талууд нь В байгууллагын өр төлбөрийн барагдуулалтыг санхүүжүүлэх үүрэгтэй гэдгийг илэрхийлнэ.

- В байгууллагын үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүний хувьд талууд эрхтэй байгаа нь тэдгээр талууд уг бүтээгдэхүүнийг хэрэглэдэг, иймээс В байгууллагын бүх үйлчилгээний чадавхи буюу хөрөнгийн бүх эдийн засгийн үр өгөөжийг хүртэх эрхтэй гэдгийг илэрхийлнэ.


Эдгээр баримт материал болон нөхцөл байдал нь уг хэлэлцээр хамтын үйл ажиллагаа болно гэдгийг илэрхийлнэ. Талууд нь бүтээгдэхүүнээс өөрт ногдох хэсгийг өөрсдийн дараагийн үйлдвэрлэлийн процессод ашиглахын оронд тухайн бүтээгдэхүүнээс өөрт ногдох хэсгийг гуравдагч талд борлуулдаг бол энэ тохиолдолд уг хамтын хэлэлцээрийг ангилах талаархи дүгнэлт өөрчлөгдөхгүй хэвээр байна.

Хэлэлцээр нь бүтээгдэхүүнээ гуравдагч талд борлуулах боломжтой байхаар талууд нь уг заавал биелүүлэх хэлцлийн нөхцлийг өөрчилсөн бол энэ нь эрэлт, бараа материал, зээлийн эрсдлийг В байгууллага өөрөө хариуцахад хүргэх юм. Уг хувилбараар авч үзвэл, баримт материал болон нөхцөл байдлын энэхүү өөрчлөлт нь тухайн хамтын хэлэлцээрийн ангиллыг дахин үнэлэхийг шаардах юм. Ийм баримт материал болон нөхцөл байдал нь уг хэлэлцээр хамтарсан үйлдвэр гэдгийг илэрхийлнэ.

- МЗУ33. Хамтын хэлэлцээрийг тусдаа бүтцээр дамжуулан зохион байгуулдаг тохиолдолд хэлэлцээрийг ангилахын тулд байгууллагын баримтлах үнэлгээг дараах блок схемд харуулав:

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

### Тусдаа бүтцээр дамжуулан зохион байгуулсан хамтын хэлэлцээрийн ангилал



### Хамтын хэлэлцээрийн оролцогч талуудын санхүүгийн тайлан (23-28-р параграф)

#### Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын тайлагнал

МЗУ33А. Байгууллага нь хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшсэн бөгөөд тэрхүү хамтын үйл ажиллагаа нь УСНББОУС 40-д тодорхойлсон, үйл ажиллагааг бүрдүүлэх тийм үйл ажиллагаа байх тохиолдолд 23-р параграфт дурдсанчлан, өөрийн хувь оролцоонд



## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

хамаарах хэмжээгээр тухайн байгууллага нь энэ Стандарт дахь заавар удирдамжтай үл зөрчилдөх, УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-д заасан худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн бүх зарчмуудыг даган мөрдөх бөгөөд худалдан авалттай холбоотойгоор тэдгээр УСНББОУС-уудад шаардсан мэдээллийг тодруулна. Энэ Стандарт дахь заавар удирдамжтай үл зөрчилдөх, худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн зарчмуудад дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Гажих нөхцлүүдийг нь УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-д зааснаас бусад, тодорхойлогдох хөрөнгө ба өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжих;
- (б) Өрийн буюу өмчийн үнэт цаас гаргах зардлыг УСНББОУС 28 ба УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрдөг гажих тохиолдлоос бусад, худалдан авалттай холбоотой өртөг зардлыг тухайн өртөг зардал гарсан ба үйлчилгээг хүлээн авсан тайлант үеүдэд зардлаар хүлээн зөвшөөрөх;
- (в) Олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн тухайн худалдан авалтын өдрөөрх цэвэр дүнгээс илүү шилжүүлсэн төлбөр хэрэв байгаа бол уг илүү давсан дүнг гүүдвил гэж хүлээн зөвшөөрөх; ба
- (г) Гүүдвиллийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг хамгийн наад зах нь жил бүр сорьж шалгах ба худалдан авалтаар олж эзэмшсэн гүүдвиллийн хувьд УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-аар шаардсанчлан, тухайн мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ буурсан шинж тэмдэг байгаа эсэхийг сорьж шалгах.

МЗУ33Б. Хамтын үйл ажиллагаанд оролцож буй талуудын нэг нь хамтын үйл ажиллагааг үүсгэн бүрдүүлэх үедээ УСНББОУС 40-д тодорхойлсны дагуу одоо оршин буй үйл ажиллагаагаар уг хамтын үйл ажиллагаанд хувь нийлүүлсэн бол, зөвхөн тийм тохиолдолд тэрхүү хамтын үйл ажиллагааны үүсгэн бүрдүүлэлтэнд 24А болон МЗУ33А параграфуудыг бас мөрдөнө. Гэвч хамтын үйл ажиллагаанд оролцож буй бүх талууд нь хамтын үйл ажиллагааг үүсгэн бүрдүүлэх үедээ үйл ажиллагаа биш, тийм хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгээр хамтын үйл ажиллагаанд хувь нийлүүлсэн зөвхөн тэр тохиолдолд уг хамтын үйл ажиллагааны үүсгэн бүрдүүлэлтэнд эдгээр параграфуудыг мөрдөхгүй.

МЗУ33В. Хамтын үйл ажиллагаа эрхлэгч нь УСНББОУС 40-д тодорхойлсны дагуу үйл ажиллагааг бүрдүүлэх хамтын үйл ажиллагаанд нэмэлт хувь оролцоог олж эзэмшснээр тэрхүү хамтын үйл ажиллагаанд дахь өөрийн хувь оролцоог нэмэгдүүлж болно. Энэ тохиолдолд хэрэв хамтын үйл ажиллагаа эрхлэгч нь хамтын хяналтаа хадгалан үлдэх бол уг хамтын үйл ажиллагаанд өмнө нь эзэмшиж байсан хувь оролцоогоо дахин хэмжихгүй.

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

МЗУ33Г. Хамтын хяналтыг хуваан эзэмшиж буй талууд, үүн дотроо хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшиж буй байгууллага нь тухайн худалдан авалтын өмнө болон дараах аль аль тохиолдолд эцсийн хяналт тавьж байгаа нэг тал буюу талуудын ерөнхий хяналтан дор байдаг бөгөөд тэрхүү хяналт нь шилждэггүй бол хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтанд 24А болон МЗУ33А-МЗУ33В параграфуудыг мөрдөхгүй.

### **Хамтын үйл ажиллагаан дахь хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлтийн тайлагнал**

МЗУ34. Өөрөө хамтын үйл ажиллагаа эрхлэгч болох байгууллага нь хөрөнгө борлуулах буюу хөрөнгөөр хувь нийлүүлэх гэх мэтээр хамтын үйл ажиллагаа бүхий ажил гүйлгээ хийсэн тохиолдолд уг байгууллага нь тэрхүү хамтын үйл ажиллагааны бусад талуудтай ажил гүйлгээ хийх бөгөөд иймээс тухайн хамтын үйл ажиллагаа эрхлэгч нь ийм ажил гүйлгээнээс үүсэх олз, гарзыг хамтын үйл ажиллагаан дахь зөвхөн бусад талуудын хувь оролцооны хэмжээгээр хүлээн зөвшөөрнө.

МЗУ35. Ийм ажил гүйлгээ нь хамтын үйл ажиллагаанд борлуулах буюу хувь нийлүүлэх хөрөнгийн цэвэр боломжит үнэ цэнийн бууралт эсвэл тэдгээр хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын талаархи нотолгоогоор хангах бол уг хамтын үйл ажиллагаа эрхлэгч нь тэдгээр гарзыг бүхэлд нь хүлээн зөвшөөрнө.

### **Хамтын үйл ажиллагаанаас авах хөрөнгийн худалдан авалтын тайлагнал**

МЗУ36. Өөрөө хамтын үйл ажиллагаа эрхлэгч болох байгууллага нь хөрөнгө худалдан авах гэх мэтээр хамтын үйл ажиллагаа бүхий ажил гүйлгээ хийсэн тохиолдолд уг байгууллага нь тэдгээр хөрөнгийг гуравдагч талд дахин борлуулах хүртэл олз, гарзаас өөрт хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй.

МЗУ37. Ийм ажил гүйлгээ нь худалдан авах хөрөнгийн цэвэр боломжит үнэ цэнийн бууралт эсвэл тэдгээр хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын талаархи нотолгоогоор хангах бол уг хамтын үйл ажиллагаа эрхлэгч нь тэдгээр гарзаас өөрт хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрнө.

## Хавсралт Б

### Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 37-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Зорилго

ДҮ1. УСНББОУС 37-гийн дүгнэлтүүдэд хүрэхдээ УСНББОУС3-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. Энэ Стандарт нь НББОУС3-өөс гаргасан, СТОУС 11, *Хамтын Хэлэлцээр* (2011 онд гаргасан ба үүн дотроо, 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүд)-т үндэслэсэн тул УСНББОУС 37 нь СТОУС 11-ийн гол шаардлагуудаас гажсан зөвхөн тэдгээр талбаруудыг Дүгнэлтийн Үндэслэлд хамруулсан.

### Тойм

ДҮ2. УСНББОУС3 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны тайлагналыг зохицуулах УСНББОУС-уудыг шинэчлэх төслийн ажлыг 2012 онд эхэлсэн. *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцоо* гэж хамтад нь нэрлэх, Саналын Төсөл (СТ) 48-52-ыг УСНББОУС3 нь 2013 оны 10 дугаар сард гаргасан. СТ 51, *Хамтын Хэлэлцээр* нь СТОУС 11, *Хамтын Хэлэлцээр*-т үндэслэсэн бөгөөд УСНББОУС 8, *Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо* дахь улсын секторын холбогдох засвар өөрчлөлтүүдийг авч үзсэн. 2015 оны 01 дүгээр сард УСНББОУС3 нь шинэ таван УСНББОУС-ыг, үүн дотроо УСНББОУС 37-г гаргасан. Эдгээр шинэ УСНББОУС-ууд нь УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 7, *Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт*, УСНББОУС 8-ыг орлох юм.

### Хамтын хэлэлцээрийн ангилал

ДҮ3. Тухайн байгууллага нь (i) хөрөнгийн хувьд эрхтэй ба өр төлбөрийн хувьд үүрэгтэй, эсвэл (ii) цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй эсэхэд үндэслэн УСНББОУС 37 нь хамтын хэлэлцээрийг хамтарсан үйлдвэр эсвэл хамтын үйл ажиллагаа гэж ангилдаг. Энэ нь УСНББОУС 8-д хамтын хяналтанд буй байгууллага, хамтын хяналтанд буй үйл ажиллагаа, хамтын хяналтанд буй хөрөнгө гэсэн хэлэлцээрийн гурван төрлөөс өөр байна. УСНББОУС 37-д заасан, хамтын хэлэлцээрийн ангилал нь СТОУС 11 дэх ангилалтай нийцсэн байвал зохино гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн.

### Нягтлан бодох бүртгэлийн сонголтыг хасах

ДҮ4. Хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч нь хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь оролцоогоо өмчийн арга ашиглан тайлагнахыг УСНББОУС 37-гоор шаарддаг. Хамтын хяналтанд буй байгууллагыг өмчийн арга эсвэл хувь тэнцүүлэн нэгтгэх аргын аль нэгийг ашиглан тайлагнахыг УСНББОУС 8-аар өмнө нь зөвшөөрдөг байсан. Хувь тэнцүүлэн нэгтгэх аргыг хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог тайлагнах арга болгон ашиглахаа болих

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

НББОУСЗ-ийн шалтгаан үндэслэлийг УСНББОУСЗ нь ойлгож мэдсэн бөгөөд УСНББОУС 37-д заасан тайлагналын арга нь СТОУС 11-тэй нийцсэн байвал зохино гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

ДҮ5. Хувь тэнцүүлэн нэгтгэх аргыг хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог тайлагнах арга болгон ашиглахаа болих НББОУСЗ-ийн шалтгаан үндэслэлд дараах зүйлс хамаарна:

- (а) Өмчийн арга нь санхүүжигчийн цэвэр хөрөнгө дэх тухайн байгууллагын хувь оролцоог тайлагнадаг арга учраас хамтарсан үйлдвэрийг тайлагнах хамгийн тохиромжтой арга юм.
- (б) СТОУС 11-д заасан хандлага нь хамтын хэлэлцээр дэх тухайн байгууллагын хувь оролцооны эдийн засгийн мөн чанарыг юу бүрдүүлдэг талаархи НББОУСЗ-ийн үзэл бодолтой нийцдэг.
- (в) СТОУС 11 нь ижил төсөөтэй эрхүүд бүхий хэлэлцээрүүдийг тууштай тайлагнахыг шаарддаг.
- (г) Хувь тэнцүүлэн нэгтгэх аргыг хасах нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллийг алдагдуулах шалтгаан болохгүй гэж НББОУСЗ нь (СТОУС 12, *Бусад Аж Ахуйн Нэгжүүд дэх Хувь Оролцооны Тодруулга* дахь тодруулгын шаардлагуудыг харгалзан үзсэнээр) дүгнэсэн.

ДҮ6. УСНББОУСЗ нь НББОУСЗ-ийн харгалзан үзсэн хандлагаас өөр арга хандлагыг зөвтгөн батлах улсын секторын ялгаатай тал байхгүй гэсэн байр суурьтай байна.

### **Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмших**

ДҮ7. УСНББОУС 37-г боловсруулж байх үед НББОУСЗ нь СТОУС 3, *Бизнесийн Нэгдэл*-д тодорхойлсон бизнесийг бүрдүүлэх хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтыг хэрхэн тайлагнах талаар шинэ заавар удирдамжийг нэмж оруулснаар СТОУС 11-д нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд санал авч байсан. 2014 оны 5 дугаар сард НББОУСЗ нь *Хамтын Үйл Ажиллагаан дахь Хувь Оролцооны Худалдан Авалтын Тайлагнал (СТОУС 11-д оруулсан Нэмэлт өөрчлөлт)*-ыг гаргасан. Улсын секторын нэгдлүүдэд хамаарах стандартын түвшний шаардлагуудын төслийг боловсруулах хүрээнд ийм заавар удирдамжийг харгалзан үзэх нь илүү тохиромжтой гэсэн үндэслэлээр УСНББОУСЗ нь уг заавар удирдамжийг УСНББОУС 37-д тусган оруулахгүй байхыг зөвшөөрсөн.

ДҮ8. УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийг боловсруулж байх үедээ УСНББОУСЗ нь үйл ажиллагааг бүрдүүлэх хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтыг хэрхэн тайлагнах талаархи заавар удирдамжийг тусган оруулах эсэхийг дахин авч үзсэн. УСНББОУСЗ нь *Хамтын Үйл Ажиллагаан дахь Хувь Оролцооны Худалдан Авалтын Тайлагнал (СТОУС 11-д оруулсан Нэмэлт өөрчлөлт)*-д НББОУСЗ-ийн оруулсан заавар удирдамжийг нягталж шалгасан ба уг заавар удирдамжаас гажих улсын секторын учир шалтгаан байхгүй гэж үзсэн.

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

Иймээс УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамжийг (УСНББОУС 40 дэх нэр томъёо ба тодорхойлолттой нийцүүлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулсан) УСНББОУС 37-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

### **2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 37-д хийсэн хянан засварлалт**

ДҮ9. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь бүх УСНББОУС дахь хэллэгт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (a) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р параграфт* нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

**ҮЛГЭРЧИЛСЭН ЖИШЭЭ**

**АГУУЛГА**

---

Барилгын ажлын үйлчилгээ	Параграф ҮЖ2-ҮЖ8
Хамтран ажиллуулдаг үйлчилгээний төв	ҮЖ9-ҮЖ13
Асрамжийн үйлчилгээний хамтарсан нөхцөл	ҮЖ14-ҮЖ20
Бүтээгдэхүүний хамтарсан үйлдвэрлэл ба түгээлт	ҮЖ21-ҮЖ35
Хамтран ажиллуулдаг банк	ҮЖ36-ҮЖ40
Газрын тос ба байгалийн хийн хайгуул, хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн ажиллагаа	ҮЖ41-ҮЖ50
Шингэрүүлсэн байгалийн хийн хэлэлцээр	ҮЖ51-ҮЖ59

---

## Үлгэрчилсэн жишээ

*Эдгээр жишээ нь УСНББОУС 37-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

ҮЖ1. Эдгээр жишээнүүд нь УСНББОУС 37-г янз бүрийн нөхцөл байдалд мөрдөх үедээ ашиглаж болох шүүн тунгаалтуудыг үлгэрчлэн харуулах таамагласан нөхцөл байдлуудыг илэрхийлнэ. Хэдийгээр эдгээр жишээний зарим төлөв байдал нь бодит нөхцөл байдалд илрэн гарч болох боловч УСНББОУС 37-г мөрдөх үедээ тухайн тодорхой хэв загварын холбогдох бүх баримт материал болон нөхцөл байдлуудыг үнэлэх шаардлагатай байдаг.

### Жишээ 1 – Барилгын ажлын үйлчилгээ

ҮЖ2. А ба Б (талууд) нь төрийн болон хувийн секторын олон төрлийн барилгын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа бүхий хоёр байгууллага юм. А байгууллага нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж юм. Б байгууллага нь төрийн өмчит байгууллага юм. Эдгээр байгууллагууд нь хоёр хотын хооронд авто замын зураг төсөл ба барилгын ажил гүйцэтгэхээр засгийн газартай байгуулсан гэрээг хэрэгжүүлэх зорилгоор хамтран ажиллах заавал биелүүлэх хэлцэл хийсэн. Уг заавал биелүүлэх хэлцэл нь А ба Б талуудын оролцооны хувь хэмжээг тодорхойлсон бөгөөд тухайн авто замыг нийлүүлэх зорилго бүхий хэлцлийн хамтарсан хяналтыг тогтоосон. Авто замын барилгын ажлыг дуусгаснаар уг хамтын хэлэлцээр нь цаашдын оролцоогүй болох юм. Барилгын ажлыг дуусгах цэг дээр уг авто замыг засгийн газарт шилжүүлэн өгнө.

ҮЖ3. Дээрх талууд нь тухайн хэлэлцээрийг хэрэгжүүлэхийн тулд тусдаа бүтцийг (Зэт байгууллагыг) үүсгэн байгуулсан. Зэт байгууллага нь А ба Б талуудын өмнөөс Засгийн газартай гэрээ байгуулна. Түүнчлэн, тухайн хэлцэлтэй холбоотой хөрөнгө, өр төлбөрийг Зэт байгууллага эзэмшинэ. Зэт байгууллагын хуулийн хэлбэрийн гол онцлог шинж нь Зэт байгууллага биш, харин дээрх талууд тухайн байгууллагын хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй байх явдал юм.

ҮЖ4. А ба Б талуудын хооронд байгуулсан заавал биелүүлэх хэлцэлд дараах зүйлсийг нэмж тусгасан:

- (а) Хэлцэлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх хөрөнгийн эрхийг эдгээр талууд нь тухайн хэлцэл дэх өөрсдийн хувь оролцоонд үндэслэн хуваан эзэмшинэ.
- (б) Тухайн хэлцэл дэх өөрсдийн хувь оролцоонд үндэслэн эдгээр талууд нь уг хэлцлийн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны болон санхүүгийн бүх үүргийн хувьд хэд хэдэн болон хамтарсан хариуцлага хүлээнэ.
- (в) Хэлцлийн үйл ажиллагааны үр дүнд үүсэх ашиг, алдагдлыг А ба Б талууд нь тухайн хэлцэл дэх өөрсдийн хувь оролцоонд үндэслэн хуваана.



## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

- ҮЖ5. Үйл ажиллагааг хамтран уялдан зохицуулах ба хянах зорилгоор А ба Б талууд нь өөрсдийн аль нэгний ажилтан байх төслийн менежерийг томилно. Тодорхой хугацааны дараа төслийн менежерийг сольж, түүний үүргийг нөгөө талын ажилтан хариуцан гүйцэтгэнэ. Үйл ажиллагааг “ашиг, алдагдалгүй” байдлаар тэдний ажилтан гүйцэтгэхийг А ба Б талууд хүлээн зөвшөөрсөн.
- ҮЖ6. Засгийн газартай байгуулсан гэрээнд тусгайлан заасан нөхцлийн дагуу Зэт байгууллага нь талуудын өмнөөс барилгын ажил гүйцэтгэх үйлчилгээний хөлсийг засгийн газраас нэхэмжилнэ.

### Шинжилгээ

- ҮЖ7. Талууд болон тусдаа бүтцийг өөр хооронд нь салган заагладаггүй (өөрөөр хэлбэл, Зэт байгууллагад эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь тухайн талуудын хөрөнгө, өр төлбөр байх) тийм хуулийн хэлбэр бүхий тусдаа бүтцээр дамжуулан уг хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлдэг. А ба Б талууд нь Зэт байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж буй хэлэлцээртэй холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй байна гэж заасан заавал биелүүлэх хэлцлээр тэдгээр талуудын тохиролцсон нөхцлийн дагуу үүнийг дахин баталгаажуулна. Энэхүү хамтын хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа юм. Энэ нь үйлчилгээний концессийн хэлцэл биш юм.
- ҮЖ8. А ба Б тал тус бүр нь өөрсдийн харилцан тохиролцсон оролцооны хувь хэмжээнд үндэслэн тухайн хэлэлцээрийн үр дүнд үүсэх хөрөнгөөс (жишээлбэл, үндсэн хөрөнгө, дансны авлага) өөрийн эзэмших хэсэг болон өр төлбөрөөс (жишээлбэл, гуравдагч этгээдэд төлөх дансны өглөг) өөрийн хариуцах хэсгийг санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрнө. Мөн тал тус бүр нь Зэт байгууллагаар дамжуулан засгийн газарт үзүүлэх барилгын ажлын үйлчилгээний үр дүн болох орлого болон зардлын өөрт хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрнө.

### Жишээ 2 - Хамтран ажиллуулдаг үйлчилгээний төв

- ҮЖ9. Хоёр байгууллага (талууд) нь хамтарсан үйлчилгээний төв байгуулж, ажиллуулах зорилгоор тусдаа бүтэц (Х байгууллага) бий болгосон. Талуудын хоорондох заавал биелүүлэх хэлцэл нь Х байгууллагын эрхлэн явуулах үйл ажиллагааны хамтын хяналтыг тогтоодог. Х байгууллагын хуулийн хэлбэрийн гол онцлог шинж нь тэдгээр талууд биш, харин Х байгууллага тэрхүү хэлэлцээртэй холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй байх явдал юм. Оффисын талбайг үйлчилгээнүүдэд хуваарилах, авто машины зогсоолыг ажиллуулах, уг төвд болон лифт гэх мэт тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх, төвийн нэр хүндийг өргөх, тус төвийн байнгын үйлчлүүлэгчдийг бий болгох нь эдгээр үйл ажиллагаанд хамаарна.

ҮЖ10. Заавал биелүүлэх хэлцлийн нөхцөл нь дараах байдалтай байна:

- (а) Х байгууллага нь тус үйлчилгээний төвийг өмчилнө. Талууд нь уг үйлчилгээний төвийн хувьд эрхтэй гэж тус заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заахгүй.
- (б) Талууд нь Х байгууллагын өр, өр төлбөр, үүргийн хувьд хариуцлага хүлээхгүй. Хэрэв Х байгууллага нь өөрийн аливаа өр болон бусад өр төлбөрийг төлж чадахгүй буюу гуравдагч талын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй бол аливаа гуравдагч этгээдийн өмнө тал тус бүрийн хүлээх хариуцлага нь тухайн талын капиталын хувь оролцооны төлөгдөөгүй дүнгээр хязгаарлагдана.
- (в) Талууд нь Х байгууллага дахь өөрсдийн хувь оролцоогоо худалдан борлуулах буюу барьцаалах эрхтэй байна.
- (г) Тал тус бүр нь тухайн үйлчилгээний төвийг ажиллуулах зардлаас өөрт хамаарах хэсгийг Х байгууллага дахь өөрийн хувь оролцооны дагуу хувааж төлнө.

### Шинжилгээ

ҮЖ11. Тусдаа бүтэц нь өөрийн эрхтэй гэж үзэхэд хүргэх (өөрөөр хэлбэл, тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь тэдгээр талуудын хөрөнгө, өр төлбөр биш, харин уг тусдаа бүтцийн хөрөнгө, өр төлбөр байх) тийм хуулийн хэлбэр бүхий тусдаа бүтцээр дамжуулан уг хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлдэг. Түүнчлэн, талууд нь уг хэлэлцээртэй холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй буюу өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэж тус заавал биелүүлэх хэлцлийн нөхцөлд тусгайлан заагаагүй. Харин талууд нь Х байгууллагын цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй гэдгийг уг заавал биелүүлэх хэлцлийн нөхцөлд тусгайлан заасан.

ҮЖ12. Дээр дурдсан тайлбар тодорхойлолтоос харвал, талууд нь тухайн хэлэлцээртэй холбоотой хөрөнгийн бараг бүх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн өгөөжийн хувьд эрхтэй ба хэлэлцээртэй холбоотой өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэдгийг илэрхийлэх бусад баримт материал болон нөхцөл байдал байхгүй байна. Энэхүү хамтын хэлэлцээр нь хамтарсан үйлдвэр юм.

ҮЖ13. Талууд нь Х байгууллагын цэвэр хөрөнгөнд хамаарах өөрсдийн эрхийг хөрөнгө оруулалт гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнийг өмчийн арга ашиглан тайлагнана.

### Жишээ 3 - Асрамжийн үйлчилгээний хамтарсан нөхцөл

ҮЖ14. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг улсын секторын байгууллага (Х байгууллага) ба үл хөдлөх хөрөнгө хөгжүүлэгч томоохон байгууллага (У байгууллага) нь настангуудад зориулсан асрамжийн үйлчилгээг үзүүлэхийн тулд хамтран ажиллахаар хэлэлцээр хийсэн. Х ба У байгууллага нь тусдаа компани (Зэт аж ахуйн нэгж)-ийг байгуулсан. Тус компанийн хуулийн хэлбэр нь хөрөнгийн эрх болон өр төлбөрийн үүргийг уг компанид өөрт нь

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

хариуцуулдаг. Х байгууллага ба У байгууллагын хоорондох хэлэлцээрийн дагуу бүх шийдвэрийг хамтран гаргах шаардлагатай байдаг. Мөн уг хэлэлцээрт дараах зүйлсийг баталгаажуулан тусгасан:

- (а) Х байгууллага нь асрамжийн үйлчилгээг үзүүлнэ. У байгууллага нь барилга, байгууламжийг барина.
- (б) Тухайн хэлэлцээрийн хөрөнгийг Зэт байгууллага буюу компани өмчилнө. Аль ч тал нь Зэт байгууллагын хөрөнгийг худалдах, барьцаалах, шилжүүлэх буюу бусад байдлаар барьцаалан зээлдэж болохгүй.
- (в) Талуудын хариуцлага нь Зэт байгууллагын аливаа төлөгдөөгүй капиталаар хязгаарлагдана.
- (г) Тал тус бүр нь тухайн үйлчилгээний төвийг ажиллуулах зардлаас өөрт хамаарах хэсгийг Зэт байгууллага дахь өөрийн хувь оролцооны дагуу хувааж төлнө.
- (д) Зэт байгууллагын ашгийг тухайн хэлэлцээр дэх талуудын харгалзах хувь оролцоогоор Х ба У байгууллагад 40:60 гэсэн харьцаагаар хуваарилна.

### Шинжилгээ

ҮЖ15. Тусдаа бүтэц нь өөрийн эрхтэй гэж үзэхэд хүргэх (өөрөөр хэлбэл, тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь тэдгээр талуудын хөрөнгө, өр төлбөр биш, харин уг тусдаа бүтцийн хөрөнгө, өр төлбөр байх) тийм хуулийн хэлбэр бүхий тусдаа бүтцээр дамжуулан уг хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлдэг. Түүнчлэн, талууд нь уг хэлэлцээртэй холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй буюу өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэж тус заавал биелүүлэх хэлцлийн нөхцөлд тусгайлан заагаагүй. Харин талууд нь Зэт байгууллагын цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй гэдгийг уг заавал биелүүлэх хэлцлийн нөхцөлд тусгайлан заасан.

ҮЖ16. Дээр дурдсан тайлбар тодорхойлолтоос харвал, талууд нь тухайн хэлэлцээртэй холбоотой хөрөнгийн бараг бүх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн өгөөжийн хувьд эрхтэй ба хэлэлцээртэй холбоотой өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэдгийг илэрхийлэх бусад баримт материал болон нөхцөл байдал байхгүй байна. Энэхүү хамтын хэлэлцээр нь хамтарсан үйлдвэр юм.

ҮЖ17. Талууд нь Зэт байгууллагын цэвэр хөрөнгөнд хамаарах өөрсдийн эрхийг хөрөнгө оруулалт гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнийг өмчийн арга ашиглан тайлагнана.

### Өөр хувилбар

ҮЖ18. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг улсын секторын байгууллага (Х байгууллага) ба үл хөдлөх хөрөнгө хөгжүүлэгч томоохон байгууллага (У байгууллага) нь настангуудад зориулсан асрамжийн үйлчилгээг үзүүлэхийн тулд хамтран ажиллахаар хэлэлцээр хийсэн. Х байгууллага ба У

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

байгууллагын хоорондох хэлэлцээрийн дагуу бүх шийдвэрийг хамтран гаргах шаардлагатай байдаг. Мөн уг хэлэлцээрт дараах зүйлсийг баталгаажуулан тусгасан:

- (а) Х байгууллага нь үйл ажиллагааны хөрөнгүүдийг, үүн дотроо оффисын тоног төхөөрөмж, автомашин, тавилга, эд хогшлыг тус асрамжийн үйлчилгээний төвд нийлүүлнэ.
- (б) У байгууллага нь барилга байгууламжийг барих бөгөөд үргэлжлүүлэн өмчилнө. У байгууллага нь тухайн барилга байгууламжийн өдөр тутмын засвар, үйлчилгээг хариуцна. У байгууллага нь тус байгууламжийг худалдан авах эрхийг Х байгууллагад эхлээд санал болгохгүйгээр тухайн барилга байгууламжийг худалдан борлуулж болохгүй. У байгууллага нь тус барилга байгууламжийн эцсийн борлуулалтын аливаа олзыг 100% хүртэх эрхтэй.
- (в) Үйлчилгээг энэ зорилгоор үүсгэн байгуулсан Зэт гэсэн шинэ байгууллагаар дамжуулан үзүүлэх юм.
- (г) Тал тус бүр нь уг үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой зардлын 50 хувийг хариуцан төлнө.
- (д) Асрамжийн үйлчилгээ үзүүлснээр олсон аливаа ашгийг Х байгууллага ба У байгууллагад тэнцүү хувааж олгоно.
- (е) Х байгууллага нь ажилтнуудыг удирдан зохицуулах ба хувь хүний гомдол саналаас үүссэн аливаа өр төлбөр, эрүүл мэндийн болон аюулгүй байдлын асуудлуудыг хариуцна.
- (ж) У байгууллага нь барилгын аливаа гэмтэл, эвдрэлийг засах, эрүүл мэндийн болон аюулгүй байдлын дүрэм журам, тэдгээр дүрэм журмын нэмэлт өөрчлөлтийг даган биелүүлэхэд шаардлагатай хэмжээгээр барилга байгууламжид засвар өөрчлөлт оруулах үүрэг хүлээнэ.

### **Өөр хувилбарын шинжилгээ**

ҮЖ19. Хэдийгээр үйлчилгээг тусдаа бүтцээр дамжуулан үзүүлдэг боловч Х ба У байгууллага нь тухайн үйлчилгээг үзүүлэхийн тулд ашиглах хөрөнгийг өмчилсөн хэвээр байна. Энэхүү хамтын хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа юм.

ҮЖ20. Х байгууллага ба У байгууллага нь өөрсдийн хөрөнгө, өр төлбөрийг өөрсдийн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрнө. Мөн тэд нь Зэт байгууллагаар дамжуулан асрамжийн үйлчилгээг үзүүлснээс бий болох орлого, зардлын өөрт хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрнө.

### **Жишээ 4 - Бүтээгдэхүүний хамтарсан үйлдвэрлэл ба түгээлт**

ҮЖ21. А ба Б байгууллагууд (талууд) нь стратегийн болон үйл ажиллагааны хэлцэл (ерөнхий хэлцэл) байгуулсан бөгөөд бүтээгдэхүүн (П бүтээгдэхүүн)

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

үйлдвэрлэж, янз бүрийн зах зээлд түгээх үйл ажиллагаа эрхлэх нөхцлийг энэхүү хэлцлээр тохиролцсон.

ҮЖ22. Талууд нь доорх байдлаар заасан хамтын хэлэлцээр байгуулах замаар уг үйлдвэрлэл ба түгээлтийн үйл ажиллагааг эрхлэн явуулахыг зөвшөөрсөн:

- (а) Үйлдвэрлэлийн ажиллагаа: Талууд нь хамтын хэлэлцээр (үйлдвэрлэлийн хэлэлцээр)-ээр дамжуулан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэн явуулахаар тохиролцсон. Тусдаа бүтэц нь өөрийн эрхтэй гэж үзэхэд хүргэх (өөрөөр хэлбэл, М тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь тэдгээр талуудын хөрөнгө, өр төлбөр биш, харин уг тусдаа бүтцийн хөрөнгө, өр төлбөр байх) тийм хуулийн хэлбэр бүхий тусдаа бүтцээр (М байгууллага) дамжуулан уг үйлдвэрлэлийн хэлэлцээрийг зохион байгуулна. Ерөнхий хэлцэлд заасанчлан, талууд нь уг үйлдвэрлэлийн хэлэлцээрийн дагуу үйлдвэрлэсэн бүх П бүтээгдэхүүнийг тэрхүү М байгууллага дахь өөрсдийн өмчлөлийн хувь оролцооны дагуу өөрсдөө худалдан авах баталгаа гаргасан. Дараа нь, тэдгээр талууд доор тайлбарласанчлан, П бүтээгдэхүүнийг зөвхөн түгээх зорилгоор өөрсдөө хамтран байгуулсан өөр нэг хэлэлцээрт тэрхүү П бүтээгдэхүүнийг борлуулна. Ерөнхий хэлцэл, түүнчлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зохицуулахын тулд А ба Б талуудын хооронд байгуулсан уг заавал биелүүлэх хэлцлийн аль алинд нь талууд тэрхүү үйлдвэрлэлийн ажиллагаатай холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэж тусгайлан заагаагүй.
- (б) Түгээлтийн ажиллагаа: Талууд нь хамтын хэлэлцээр (түгээлтийн хэлэлцээр)-ээр дамжуулан түгээлтийн үйл ажиллагааг эрхлэн явуулахаар тохиролцсон. Тусдаа бүтэц нь өөрийн эрхтэй гэж үзэхэд хүргэх (өөрөөр хэлбэл, Г тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь тэдгээр талуудын хөрөнгө, өр төлбөр биш, харин уг тусдаа бүтцийн хөрөнгө, өр төлбөр байх) тийм хуулийн хэлбэр бүхий тусдаа бүтцээр (Г байгууллага) дамжуулан уг түгээлтийн хэлэлцээрийг зохион байгуулна. Ерөнхий хэлцэлд заасанчлан, түгээлтийн хэлэлцээрээр тухайн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах янз бүрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагын дагуу уг түгээлтийн хэлэлцээр нь тэдгээр талуудаас авах П бүтээгдэхүүний өөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлно. Ерөнхий хэлцэл, түүнчлэн түгээлтийн үйл ажиллагааг зохицуулахын тулд А ба Б талуудын хооронд байгуулсан уг заавал биелүүлэх хэлцлийн аль алинд нь талууд тэрхүү түгээлтийн ажиллагаатай холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэж тусгайлан заагаагүй.

ҮЖ23. Мөн түүнчлэн, Ерөнхий хэлцэлд дараах зүйлсийг тогтоон тусгасан:

- (а) Түгээлтийн хэлэлцээрээр талуудын тодорхойлсон П бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлагыг хангахын тулд үйлдвэрлэлийн хэлэлцээр нь П бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ;

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

- (б) Үйлдвэрлэлийн хэлэлцээрээр П бүтээгдэхүүнийг талуудад борлуулахтай холбоотой худалдаа арилжааны нөхцөл. Үйлдвэрлэлийн хэлэлцээр нь гарсан үйлдвэрлэлийн бүх өртөг зардлыг нөхөх бөгөөд А ба Б талуудын зөвшөөрсөн үнээр уг П бүтээгдэхүүнийг талуудад худалдан борлуулна. Дараа нь, талууд уг бүтээгдэхүүнийг А ба Б талуудын зөвшөөрсөн үнээр уг түгээлтийн хэлэлцээрт худалдан борлуулна.
- (в) Үйлдвэрлэлийн хэлэлцээрийн хувьд үүсэж болох мөнгөний аливаа хүрэлцээгүй дутагдлыг талууд нь М байгууллага дахь өөрсдийн өмчлөлийн хувь оролцооны дагуу санхүүжүүлнэ.

### Шинжилгээ

ҮЖ24. А ба Б талууд нь П бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба түгээлтийг эрхлэн явуулах нөхцлийг Ерөнхий хэлцэлд тодорхойлсон. П бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх эсвэл түгээх зорилго бүхий хамтын хэлэлцээрээр дамжуулан эдгээр ажиллагааг эрхлэн явуулна.

ҮЖ25. Талууд болон тусдаа бүтцийг өөр хооронд нь салган зааглах тийм хуулийн хэлбэр бүхий М байгууллагаар дамжуулан талууд нь үйлдвэрлэлийн хэлэлцээрийг хэрэгжүүлнэ. Мөн Ерөнхий хэлцэл, түүнчлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зохицуулахын тулд байгуулсан уг заавал биелүүлэх хэлцлийн аль алинд нь талууд тэрхүү үйлдвэрлэлийн ажиллагаатай холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэж тусгайлан заагаагүй. Гэвч дараах баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзсэнээр үйлдвэрлэлийн хэлэлцээр нь хамтын үйл ажиллагаа гэж тэдгээр талууд дүгнэсэн:

- (а) Талууд нь уг үйлдвэрлэлийн хэлэлцээрийн дагуу үйлдвэрлэсэн бүх П бүтээгдэхүүнийг өөрсдөө худалдан авах баталгаа гаргасан. Иймээс А ба Б талууд нь үйлдвэрлэлийн хэлэлцээрийн хөрөнгийн бараг бүх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн өгөөжийн хувьд эрхтэй байна.
- (б) Талууд нь түгээлтийн хэлэлцээрийн П бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг хангах боломжтой байхын тулд үйлдвэрлэлийн хэлэлцээр нь тэдгээр талуудын тоо хэмжээний болон чанарын хэрэгцээ шаардлагыг хангах тийм П бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ. Үйлдвэрлэлийн хэлэлцээр нь мөнгөн гүйлгээг үүсгэн бий болгохдоо талуудаас, түүнчлэн үйлдвэрлэлийн хэлэлцээрт мөнгөний аливаа дутагдал хүрэлцээгүй байдал үүссэн тохиолдолд мөнгө сангаар хангах тэдгээр талуудын баталгаанаас бүрэн хамааралтай байдал нь талууд уг үйлдвэрлэлийн хэлэлцээрийн өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэдгийг илэрхийлнэ. Яагаад гэвэл, тэдгээр өр төлбөрийг талууд П бүтээгдэхүүнийг худалдан авснаар эсвэл талууд шууд мөнгө хөрөнгө оруулснаар барагдуулах юм.

ҮЖ26. Талууд болон тухайн байгууллагыг өөр хооронд нь салган зааглах тийм хуулийн хэлбэр бүхий Г байгууллагаар дамжуулан талууд нь түгээлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Мөн Ерөнхий хэлцэл, түүнчлэн түгээлтийн

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

үйл ажиллагааг зохицуулахын тулд байгуулсан уг заавал биелүүлэх хэлцлийн аль алинд нь талууд тэрхүү түгээлтийн ажиллагаатай холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэж тусгайлан заагаагүй.

- ҮЖ27. Талууд нь тухайн түгээлтийн хэлэлцээртэй холбоотой хөрөнгийн бараг бүх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн өгөөжийн хувьд эрхтэй ба тэрхүү хэлэлцээртэй холбоотой өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэдгийг илэрхийлэх бусад баримт материал болон нөхцөл байдал байхгүй. Энэхүү түгээлтийн хэлэлцээр нь хамтарсан үйлдвэр юм.
- ҮЖ28. А ба Б тал тус бүр нь тухайн үйлдвэрлэлийн хэлэлцээрийн үр дүнд үүсэх хөрөнгөөс (жишээлбэл, үндсэн хөрөнгө, мөнгө) өөрийн эзэмших хэсэг болон өр төлбөрөөс (жишээлбэл, гуравдагч этгээдэд төлөх дансны өглөг) өөрийн хариуцах хэсгийг санхүүгийн тайландаа М байгууллага дахь өөрсдийн өмчлөлийн хувь оролцоонд үндэслэн хүлээн зөвшөөрнө. Мөн тал тус бүр нь үйлдвэрлэлийн хэлэлцээрийн дагуу П бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхтэй холбоотойгоор гарсан өртөг зардлаас өөрт хамаарах хэсгийг, түүнчлэн түгээлтийн хэлэлцээрийн дагуу П бүтээгдэхүүнийг борлуулснаар үүсэх орлогоос өөрт хамаарах хэсгийг тус тус хүлээн зөвшөөрнө.
- ҮЖ29. Талууд нь түгээлтийн хэлэлцээрийн цэвэр хөрөнгөнд хамаарах өөрсдийн эрхийг хөрөнгө оруулалт гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнийг өмчийн арга ашиглан тайлагнана.

### Өөр хувилбар

- ҮЖ30. Дээр дурдсан үйлдвэрлэлийн хэлэлцээр нь зөвхөн П бүтээгдэхүүний үйлдвэрлэл төдийгүй уг бүтээгдэхүүнийг гуравдагч тал болох хэрэглэгчдэд түгээх ажиллагааг бас хариуцахыг талууд хүлээн зөвшөөрсөн гэж үзье.
- ҮЖ31. Тодорхой нэмэлт зах зээлд П бүтээгдэхүүний түгээлтийг нэмэгдүүлэхэд зөвхөн туслах үүднээс П бүтээгдэхүүнийг түгээх дээр дурдсантай адил түгээлтийн хэлэлцээр хийх талууд мөн хүлээн зөвшөөрсөн.
- ҮЖ32. Үйлдвэрлэлийн хэлэлцээр нь П бүтээгдэхүүнийг уг түгээлтийн хэлэлцээрт мөн шууд борлуулдаг. Үйлдвэрлэлийн хэлэлцээрийн дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тогтмол хувь хэмжээг уг түгээлтийн хэлэлцээрээр худалдан авах буюу түүнд зориулан нөөцлөн хадгалах баталгаа гаргаагүй.

### Өөр хувилбарын шинжилгээ

- ҮЖ33. Энэхүү өөр хувилбар нь үйлдвэрлэлийн ажиллагааг эрхлэн явуулах тусдаа бүтцийн хуулийн хэлбэр, түүнчлэн тухайн үйлдвэрлэлийн ажиллагаанд хамаарах талуудын хөрөнгийн эрх болон өр төлбөрийн үүрэгтэй холбоотой заавал биелүүлэх нөхцлийн аль алинд нөлөө үзүүлэхгүй. Гэвч энэ нь уг үйлдвэрлэлийн хэлэлцээр өөрийгөө санхүүжүүлэх хэлэлцээр болоход хүргэнэ. Яагаад гэвэл, тус хэлэлцээр нь худалдаа арилжааг өөрийн нэрээр эрхлэн явуулах, П бүтээгдэхүүнийг гуравдагч талын хэрэглэгчдэд түгээх ба

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

ингэснээр эрэлтийн, бараа материалын, зээлийн эрсдлийг өөрөө хариуцах чадвар боломжтой байдаг. Хэдийгээр үйлдвэрлэлийн хэлэлцээр нь П бүтээгдэхүүнийг уг түгээлтийн хэлэлцээрт бас борлуулж болох боловч энэ тохиолдолд тухайн үйлдвэрлэлийн хэлэлцээр нь өөрийн үйл ажиллагааг тасралтгүй байдлаар эрхлэн явуулах чадвар боломжийн хувьд тэдгээр талуудаас хараат бус байна. Ийм нөхцөлд уг үйлдвэрлэлийн хэлэлцээр нь хамтарсан үйлдвэр болно.

ҮЖ34. Энэхүү өөр хувилбар нь уг түгээлтийн хэлэлцээрийг хамтарсан үйлдвэр гэж ангилах ангилалд нөлөө үзүүлэхгүй.

ҮЖ35. Талууд нь үйлдвэрлэлийн хэлэлцээрийн цэвэр хөрөнгөнд хамаарах өөрсдийн эрх ба түгээлтийн хэлэлцээрийн цэвэр хөрөнгөнд хамаарах өөрсдийн эрхийг хөрөнгө оруулалт гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд эдгээрийг өмчийн арга ашиглан тайлагнана.

### **Жишээ 5 - Хамтран ажиллуулдаг банк**

ҮЖ36. Төрийн өмчит А банк ба хувийн хэвшлийн Б банк (талууд) нь тусдаа бүтэц (В банк) бий болгох замаар корпорацийн, хөрөнгө оруулалтын банкны, хөрөнгийн менежментийн болон үйлчилгээний зарим үйл ажиллагааг нэгтгэн явуулахаар тохиролцсон. Талуудын аль аль нь уг хэлэлцээрээс янз бүрийн арга замаар үр өгөөж хүртэнэ гэж хүлээж байна. А банк нь бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлэн санал болгосноор өөрийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх стратегийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх боломжийг уг хэлэлцээр олгоно гэж найдаж байна. Б банк нь уг хэлэлцээрээр өөрийн санхүүгийн хадгаламжийн болон зах зээлийн бүтээгдэхүүний санал болголтоо дахин бэхжүүлнэ гэж хүлээж байна.

ҮЖ37. В банкны хуулийн хэлбэрийн гол шинж чанар нь уг тусдаа бүтэц өөрийн эрхтэй гэж үзэхэд хүргэх (өөрөөр хэлбэл, тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь тэдгээр талуудын хөрөнгө, өр төлбөр биш, харин уг тусдаа бүтцийн хөрөнгө, өр төлбөр байх) явдал юм. А ба Б банк тус бүр нь уг В банкны 40 хувийн өмчлөлийн хувь оролцоог эзэмшдэг бөгөөд үлдсэн 20 хувийг биржээр дамжуулан олон нийт эзэмшдэг. А ба Б банкны хооронд байгуулсан хэлэлцээр нь В банкны үйл ажиллагаанд хамтын хяналт тогтоодог.

ҮЖ38. Түүнчлэн, А ба Б банк нь үл цуцлагдах хэлэлцээр хийсэн бөгөөд хэдийгээр маргаан үүссэн ч гэсэн уг хэлэлцээрийн дагуу хоёр банкны аль аль нь шаардлагатай мөнгө санг тэнцүү дүнгээр гаргах, холбогдох хууль тогтоомж ба банкны зохицуулалтыг В банк даган мөрдөж буй эсэхийг хэрэв шаардлагатай бол хамтран болон тус тусдаа шалган магадлах, тухайн банкны салбарын эрх бүхий байгууллагад гаргасан аливаа баталгааг үнэнч шударгаар биелүүлэхийг хүлээн зөвшөөрсөн. Энэхүү баталгаа нь хууль тогтоомж болон банкны зохицуулалтыг В банк даган мөрдөж буй эсэхийг шалган магадлахад шаардлагатай аливаа мөнгө санг тал тус бүр 50 хувиар хариуцна гэсэн утгыг илэрхийлнэ.



## Шинжилгээ

- ҮЖ39. Талууд болон тусдаа бүтцийг өөр хооронд нь салган заагладаггүй тийм хуулийн хэлбэр бүхий тусдаа бүтцээр дамжуулан уг хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлдэг. Талууд нь В банкны хөрөнгийн хувьд эрхтэй буюу өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэж уг заавал биелүүлэх хэлцлийн нөхцөлд тусгайлан заагаагүй, харин В банкны цэвэр хөрөнгийн хувьд талууд эрхтэй гэдгийг тогтоосон. Хэрэв В банк холбогдох хууль тогтоомж болон банкны зохицуулалтыг даган мөрдөх боломжгүй бол дэмжлэг үзүүлэхээр талуудын гаргасан баталгаа нь тэрхүү В банкны өр төлбөрийн хувьд талууд үүрэгтэй гэдгийг дангаараа тодорхойлох үзүүлэлт болохгүй юм. Талууд нь В банкны хөрөнгийн бараг бүх эдийн засгийн өгөөжийн хувьд эрхтэй ба В банкны өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэдгийг илэрхийлэх бусад баримт материал болон нөхцөл байдал байхгүй. Энэхүү хамтын хэлэлцээр нь хамтарсан үйлдвэр юм.
- ҮЖ40. А ба Б банкны аль аль нь В банкны цэвэр хөрөнгөнд хамаарах өөрсдийн эрхийг хөрөнгө оруулалт гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд тэдгээрийг өмчийн арга ашиглан тайлагнана.

## Жишээ 6 - Газрын тос ба байгалийн хийн хайгуул, хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн ажиллагаа

- ҮЖ41. А ба Б байгууллагууд (талууд) нь О улсад газрын тос ба байгалийн хийн хайгуул, хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэн явуулахын тулд тусдаа бүтцийг (Эйч байгууллагыг) үүсгэж, Хамтран Ажиллах Хэлэлцээр (ХАХ) байгуулсан. Эйч байгууллагын хуулийн хэлбэрийн гол шинж чанар нь уг тусдаа бүтэц өөрийн эрхтэй гэж үзэхэд хүргэх (өөрөөр хэлбэл, тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь тэдгээр талуудын хөрөнгө, өр төлбөр биш, харин уг тусдаа бүтцийн хөрөнгө, өр төлбөр байх) явдал юм.
- ҮЖ42. О улс нь тусгайлан тогтоосон тодорхой газар (талбар)-т газрын тос ба байгалийн хийн хайгуул, хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг Эйч байгууллагад олгосон.
- ҮЖ43. Талуудын хийсэн хэлэлцээр ба байгуулсан ХАХ нь уг үйл ажиллагаатай холбоотой талуудын эрх ба үүргийг тодорхойлдог. Эдгээр хэлэлцээрүүдийн гол нөхцлүүдийг доор нэгтгэн харуулав.

## Тохиролцоо

- ҮЖ44. Эйч байгууллагын удирдах зөвлөл нь тал тус бүрээс томилогдсон захирлуудаас бүрдэнэ. Тал тус бүр нь Эйч байгууллагын 50 хувийг эзэмшинэ. Аливаа шийдвэрийг гаргахын тулд захирлуудын санал нэгтэй зөвшөөрлийг шаарддаг.

**Хамтран Ажиллах Хэлэлцээр (ХАХ)**

- ҮЖ45. ХАХ-ээр Үйл Ажиллагааны Хороог байгуулсан. Энэхүү Хороо нь тал тус бүрээс томилогдсон нэг төлөөлөгчөөс бүрддэг. Тал тус бүр нь уг Үйл Ажиллагааны Хороонд 50 хувийн хувь оролцоотой байна.
- ҮЖ46. Үйл Ажиллагааны Хороо нь үйл ажиллагаатай холбоотой төсөв болон ажлын хөтөлбөрийг баталдаг бөгөөд ингэж батлахдаа мөн тал тус бүрийн төлөөлөгчдийн санал нэгтэй зөвшөөрлийг шаарддаг. Талуудын аль нэгийг оператор болгон томилдог бөгөөд энэ нь уг батлагдсан ажлын хөтөлбөрийг удирдан зохицуулах ба хэрэгжүүлэх хариуцлага хүлээдэг.
- ҮЖ47. Хайгуул, хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүн болох эрх ба үүргийг уг Эйч байгууллага дахь тал тус бүрийн эзэмшилтэй хувь тэнцүүлэн тэдгээр талуудад хуваарилахаар ХАХ-д заасан. Тухайлбал; дараах зүйлсийг талуудад хуваарилах талаар ХАХ-д заасан:
- (а) Эйч байгууллагад олгосон хайгуул болон хөгжүүлэлтийн зөвшөөрлийн үр дүн болох эрх ба үүрэг (жишээлбэл; тэдгээр зөвшөөрлүүд, нөхөн сэргээлтийн үүрэг, аливаа эрхийн шимтгэлийн болон татварын өглөг);
  - (б) Олж авсан бүтээгдэхүүн; ба
  - (в) Ажлын бүх хөтөлбөртэй холбоотой нийт өртөг зардал.
- ҮЖ48. Ажлын бүх хөтөлбөртэй холбоотойгоор гарсан өртөг зардлуудыг талуудаас авах мөнгөөр төлж барагдуулна. Хэрэв аль нэг тал нь мөнгө төлөх өөрийн үүргийг биелүүлээгүй бол нөгөө тал нь төлөгдөөгүй байгаа дүнг Эйч байгууллагад олгох шаардлагатай. Уг төлөгдөөгүй дүн нь тэрхүү үүргээ биелүүлээгүй тал нөгөө талдаа өгөх өглөг гэж үзнэ.

**Шинжилгээ**

- ҮЖ49. Талууд болон тусдаа бүтцийг өөр хооронд нь салган зааглах тийм хуулийн хэлбэр бүхий тусдаа бүтцээр дамжуулан талууд нь уг хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлнэ. Эдгээр талууд нь энэхүү хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх уг тусдаа бүтцийн хуулийн хэлбэрээс үүсэх өөрсдийн эрх ба үүргийн анхны үнэлгээг буцаах боломжтой байдаг. Талууд нь Эйч Х байгууллагад эзэмшиж буй хөрөнгийн (жишээлбэл; эдгээр үйл ажиллагаанаас үүсэх хайгуул ба хөгжүүлэлтийн зөвшөөрөл, үйлдвэрлэлийн болон бусад аливаа хөрөнгүүдийн) хувьд эрх олгодог, өр төлбөрийн хувьд үүрэг (жишээлбэл; ажлын хөтөлбөрүүдээс үүсэх бүх өртөг зардал ба ба үүргүүд) хүлээлгэдэг ХАХ-ийн нөхцлүүдийг хүлээн зөвшөөрснөөр үүнийг хэрэгжүүлдэг. Энэхүү хамтын хэлэлцээр нь хамтарсан үйлдвэр юм.
- ҮЖ50. А ба Б байгууллагын аль аль нь өөрсдийн тохиролцсон оролцооны хувь хэмжээнд үндэслэн уг хэлэлцээрийн үр дүн болох тэдгээр хөрөнгө болон аливаа өр төлбөрийн хэсгийг санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрнө. Тал тус бүр нь (бүтээгдэхүүний өөрт ногдох хэсгийн борлуулалтаас үүсэх)

орлогын өөрт хамаарах хэсэг болон зардлын өөрт хамаарах хэсгийг мөн энэхүү сууриар хүлээн зөвшөөрнө.

## Жишээ 7 - Шингэрүүлсэн байгалийн хийн хэлэлцээр

- ҮЖ51. А байгууллага нь байгалийн хийн их хэмжээний нөөц бүхий байгалийн хийн хөгжүүлэлт хийгдээгүй талбарыг өмчилдөг. Байгалийн хийг зөвхөн гадаад зах зээлд борлуулсан тохиолдолд уг байгалийн хийн талбар нь эдийн засгийн хувьд үр ашигтай байна гэж А байгууллага тодорхойлсон. Гадаад зах зээлд усан онгоцоор тээвэрлэх боломжтой болгохын тулд уг байгалийн хийг шингэрүүлэх үүднээс шингэрүүлсэн байгалийн хий (ШБХ)-н үйлдвэрийг барих шаардлагатай.
- ҮЖ52. А байгууллага нь уг байгалийн хийн талбарыг хөгжүүлж, ШБХ-н үйлдвэрийг ажиллуулахын тулд Б байгууллагатай хамтын хэлэлцээр байгуулсан. Энэхүү хэлэлцээрийн дагуу А ба Б байгууллагууд (талууд) нь шинэ тусдаа бүтэц болох В байгууллагад байгалийн хийн талбар болон мөнгөөр тус тус хувь оруулахыг хүлээн зөвшөөрсөн. Эдгээр хувь оролцооны хариуд тал тус бүр нь В байгууллагын өмчлөлийн хувь оролцооны 50 хувийг эзэмшинэ. В байгууллагын хуулийн хэлбэрийн гол шинж чанар нь уг тусдаа бүтэц өөрийн эрхтэй гэж үзэхэд хүргэх (өөрөөр хэлбэл, тусдаа бүтцэд эзэмшүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь тэдгээр талуудын хөрөнгө, өр төлбөр биш, харин уг тусдаа бүтцийн хөрөнгө, өр төлбөр байх) явдал юм.
- ҮЖ53. Талуудын хооронд байгуулсан заавал биелүүлэх хэлцэлд дараах байдлаар тусгайлан заасан:
- (а) А ба Б байгууллагууд нь В байгууллагын захирлуудын зөвлөлд тус бүр хоёр гишүүнийг томилох ёстой. Захирлуудын зөвлөл нь В байгууллагын боловсруулсан стратеги ба хийсэн хөрөнгө оруулалтыг санал нэгтэй зөвшөөрөх ёстой.
  - (б) Байгалийн хийн талбар болон ШБХ-ийн үйлдвэрийн өдөр тутмын менежментийг, үүн дотроо хөгжүүлэлт ба барилгын үйл ажиллагааг Б байгууллагын ажилтнууд нь талуудын хамтран зөвшөөрсөн удирдамж чиглэлийн дагуу гүйцэтгэнэ. В байгууллага нь байгалийн хийн талбар болон ШБХ-ийн үйлдвэрийг удирдан зохицуулахтай холбоотойгоор гаргасан өртөг зардлыг Б байгууллагад нөхөн төлнө.
  - (в) В байгууллага нь ШБХ-н үйлдвэрлэл, борлуулалтанд хамаарах татвар, эрхийн шимтгэл, түүнчлэн дансны өглөг, талбарын нөхөн сэргээлт, хаалтын өр төлбөр гэх мэт бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад үүссэн бусад өр төлбөрийг хариуцна.
  - (г) А ба Б байгууллагууд нь В байгууллагаас олгосон аливаа ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг тэнцүү авах эрхтэй гэх мэтээр уг хэлэлцээрийн дагуу гүйцэтгэсэн үйл ажиллагааны ашгийн хувьд тэнцүү хувь оролцоотой байна.
- ҮЖ54. Аль нэг тал нь В байгууллагын хөрөнгийн хувьд эрхтэй буюу өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэж уг заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заагаагүй.

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

- ҮЖ55. Байгалийн хийн талбарын хөгжүүлэлт ба ШБХ-н үйлдвэр барих санхүүжилтэнд тусгалцаа үзүүлэхийн тулд В байгууллагын захирлуудын зөвлөл нь зээлдүүлэгчдийн нэгдэлтэй санхүүжилтийн хэлцэл байгуулахаар шийдвэрлэсэн. Хөгжүүлэлтийн болон барилгын ажлын тооцоолсон нийт өртөг нь 1,000 сая ТН<sup>1</sup> байсан.
- ҮЖ56. Зээлийн нэгдэл нь В байгууллагад 700 сая ТН-ийн зээл олгосон. В байгууллага нь талбарын хөгжүүлэлт болон ШБХ-н үйлдвэрийг барьж байгуулах явцад зээлийн хэлцлийг үл биелүүлсэн зөвхөн тийм тохиолдолд уг нэгдэл нь А ба Б байгууллагуудаас баталгаа шаардана гэж зээлийн хэлцэлд тусгайлан заасан. ШБХ-н борлуулалтаас В байгууллагын олох мөнгөн орлогын гүйлгээ нь зээлийг буцаан төлөхөд хангалттай гэж үнэлсэн учраас уг зээлийн нэгдэл нь ШБХ-н үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлмэгц А ба Б байгууллагуудаас баталгаа шаардахгүй байхыг хүлээн зөвшөөрсөн. Хэдийгээр зээлдүүлэгчид нь энэ хугацаанд А ба Б байгууллагуудаас баталгаа шаардаагүй боловч ШБХ-н үйлдвэрийг барьцаалснаар В байгууллагын зээлийн төлбөрийн үл биелүүлэлтийн хувьд хамгаалалт бүрдүүлсэн.

### Шинжилгээ

- ҮЖ57. Талууд болон тусдаа бүтцийг өөр хооронд нь салган заагладаг тийм хуулийн хэлбэр бүхий тусдаа бүтцээр дамжуулан уг хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлдэг. Талууд нь В байгууллагын хөрөнгийн хувьд эрхтэй буюу өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэж уг заавал биелүүлэх хэлцлийн нөхцөлд тусгайлан заагаагүй, харин В байгууллагын цэвэр хөрөнгийн хувьд талууд эрхтэй гэдгийг тогтоосон. Байгалийн хийн талбарын хөгжүүлэлт ба ШБХ-н үйлдвэрийн барилгын ажлын явц дахь санхүүжилтийн хэлцлийн баталгааны шинж чанар (өөрөөр хэлбэл, А ба Б байгууллагууд нь энэ үе шатанд тусдаа баталгаа гаргах) нь В байгууллагын өр төлбөрийн хувьд тэдгээр талуудад үүргийг хүлээлгэх үндэслэл болохгүй (өөрөөр хэлбэл, уг зээл нь В байгууллагын өр төлбөр) юм. А ба Б байгууллагууд нь тусдаа өр төлбөртэй өөрөөр хэлбэл, энэ нь хөгжүүлэлтийн болон барилгын ажлын үе шатны явцад В байгууллага төлбөрийн үүргээ биелүүлээгүй бол тухайн зээлийг буцаан төлөх баталгаа юм.
- ҮЖ58. Талууд нь В байгууллагын хөрөнгийн бараг бүх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн өгөөжийн хувьд эрхтэй ба В байгууллагын өр төлбөрийн хувьд үүрэгтэй гэдгийг илэрхийлэх бусад баримт материал болон нөхцөл байдал байхгүй байна. Энэхүү хамтын хэлэлцээр нь хамтарсан үйлдвэр юм.
- ҮЖ59. Талууд нь В байгууллагын цэвэр хөрөнгөнд хамаарах өөрсдийн эрхийг хөрөнгө оруулалт гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд үүнийг өмчийн арга ашиглан тайлагнана.

---

<sup>1</sup> Энэ жишээнд мөнгөн дүнг “тоолох нэгж (ТН)” гэж тэмдэглэсэн.

**Жишээ 8 – Үйл ажиллагааг бүрдүүлдэг хамтарсан үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын тайлагнал**

- ҮЖ60. А, Б, В хотын захиргаанууд нь УСНББОУС 40 Улсын Секторын Нэгдэл-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэх тийм үйл ажиллагаа бүхий Г Хамтын Үйл Ажиллагааг хамтран хянадаг.
- ҮЖ61. Д хотын захиргаа нь уг Г Хамтын Үйл Ажиллагаан дахь А хотын захиргааны 40 хувийн өмчлөлийн хувь оролцоог 300ТН-ээр худалдан авсан ба уг худалдан авалттай холбоотойгоор 50ТН-ийн зардал гаргасан.
- ҮЖ62. Энэхүү худалдан авалтын нэг хэсэг байдлаар Д хотын захиргааны нэгдэн орсон, талуудын хооронд байгуулсан заавал биелүүлэх хэлцэлд зааснаар, зарим хөрөнгө, өр төлбөр дэх Д хотын захиргааны хувь хэмжээ нь уг Г Хамтын Үйл Ажиллагаан дахь түүний өмчлөлийн хувь хэмжээнээс өөр байх юм. Талуудын хооронд байгуулсан уг заавал биелүүлэх хэлцэлд заасанчлан, Г Хамтын Үйл Ажиллагаатай холбоотой хөрөнгө, өр төлбөр дэх Д хотын захиргааны эзэмших хувь хэмжээг дараах хүснэгтэнд харуулсан:

<b>Г Хамтын Үйл Ажиллагаатай холбоотой хөрөнгө, өр төлбөр дэх Д хотын захиргааны хувь хэмжээ</b>	
Үндсэн хөрөнгө	48%
Биет бус хөрөнгө (гүүдвил хамаарахгүй)	90%
Дансны авлага	40%
Бараа материал	40%
Тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн өглөг	15%
Дансны өглөг	40%
Болзошгүй өр төлбөр	56%

**Шинжилгээ**

- ҮЖ63. Д хотын захиргаа нь гэрээт хэлэлцээрийн үр дүн болох тэдгээр хөрөнгө, өр төлбөрөөс өөрт хамаарах хэсгийг санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрнө (23-р параграфыг үзнэ үү).
- ҮЖ64. Д хотын захиргаа нь Г Хамтын Үйл Ажиллагаан дахь уг хувь оролцоог худалдан авснаар олж эзэмшсэн хөрөнгө, хариуцсан өр төлбөрийн танин тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, ангиллын хувьд УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-д заасан худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг мөрдөнө. Яагаад гэвэл, Д хотын захиргаа нь үйл ажиллагааг бүрдүүлэх тийм ажиллагаа бүхий хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог худалдан авсан (24А параграфыг үзнэ үү).
- ҮЖ65. Гэвч энэ Стандартад заасан заавар удирдамжтай зөрчилдөх тохиолдолд Д хотын захиргаа нь УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-ын худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг мөрдөхгүй. Иймээс 23-р параграфт заасанчлан, Г Хамтын Үйл Ажиллагаан дахь өөрийн хувь оролцоотой холбоотойгоор Д хотын захиргаа нь зөвхөн хамтран эзэмшиж буй хөрөнгө нэг бүр дэх өөрийн хувь хэмжээ болон хамтран хариуцах өр

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

төлбөр нэг бүр дэх өөрийн хувь хэмжээг тэрхүү заавал биелүүлэх хэлцэлд заасан хэмжээгээр хүлээн зөвшөөрч, хэмжинэ. Д хотын захиргаа нь Г Хамтын Үйл Ажиллагаан дахь бусад талуудын хувь оролцооны хэсгийг өөрийн хөрөнгө, өр төлбөрийн оруулан тусгахгүй.

- ҮЖ66. Цөөн гажих нөхцөлтэй боловч нэгтгэгч нь олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийг тэдгээрийн олж эзэмшсэн өдрийн бодит үнэ цэнээр хэмжихийг УСНББОУС 40-д шаардсан байдаг. Жишээлбэл; биет бус хөрөнгө байдлаар хүлээн зөвшөөрсөн уг дахин олж эзэмшсэн эрхийн бодит үнэ цэнийг хэмжих үедээ зах зээлийн оролцогч нар нь заавал биелүүлэх хэлцлийг дахин шинэчлэх боломжит байдлыг харгалзан үздэг эсэхээс үл хамааран тэрхүү холбогдох заавал биелүүлэх хэлцлийн үлдсэн хугацаанд үндэслэн тухайн эрхийг хэмждэг. Ийм хэмжилт нь энэ Стандарттай зөрчилдөхгүй тул тэдгээр шаардлагуудыг дагаж мөрдөнө.
- ҮЖ67. Иймээс Д хотын захиргаа нь Г Хамтын Үйл Ажиллагаатай холбоотой уг тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн өөрт хамаарах хэсгийн бодит үнэ цэнэ буюу УСНББОУС 40-д заасан бусад хэмжилтийг тодорхойлно. Г Хамтын Үйл Ажиллагаатай холбоотой тэдгээр тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрөөс Д хотын захиргаанд хамаарах хэсгийн бодит үнэ цэнэ буюу УСНББОУС 40-д заасан бусад хэмжилтийг дараах хүснэгтэнд харуулсан:

<b><i>Г Хамтын Үйл Ажиллагааны тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрөөс Д хотын захиргаанд хамаарах хэсгийн бодит үнэ цэнэ буюу УСНББОУС 40-д заасан бусад хэмжилт</i></b>	
<b>(ТН)</b>	
Үндсэн хөрөнгө	138
Биет бус хөрөнгө (гүүдвил хамаарахгүй)	72
Дансны авлага	84
Бараа материал	70
Тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн өглөг	(12)
Дансны өглөг	(48)
Болзошгүй өр төлбөр	(52)
Хойшлогдсон татварын өр төлбөр (орлогын татварыг зохицуулдаг олон улсын буюу үндэсний стандартыг үзнэ үү)	(24)
<b>Цэвэр хөрөнгө</b>	<b><u>228</u></b>

- ҮЖ68. Тодорхойлогдох цэвэр хөрөнгөөс Д хотын захиргаанд хамаарах хэсэгт хуваарилсан дүнгээс давж хэтэрсэн, уг шилжүүлсэн төлбөрийн дүнг УСНББОУС 40-ийн дагуу гүүдвил гэж хүлээн зөвшөөрнө:

Шилжүүлсэн төлбөр	300 ТН
Хамтын үйл ажиллагаан дахь түүний хувь оролцоотой холбоотой уг тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрөөс Д хотын захиргаанд хамаарах хэсэг	<u>228 ТН</u>
<b>Цэвэр хөрөнгө</b>	<b><u>72 ТН</u></b>

ҮЖ69. Худалдан авалттай холбоотой 50ТН-ийн зардлыг уг хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж авахын тулд шилжүүлсэн төлбөрийн нэг хэсэг гэж үзэхгүй. Үүнийг тухайн зардал гарсан ба үйлчилгээг хүлээн авсан тайлант үеийн ашиг, алдагдалд зардал гэж хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 40-ийн 111-р параграфыг үзнэ үү).

### **Жишээ 9 –Үйл ажиллагааг бүрдүүлдэг хамтын үйл ажиллагаанд ноу-хау ашиглах эрхээр хувь оруулах**

ҮЖ70. А ба Б байгууллагууд нь янз бүрийн хэрэгцээнд зориулсан өндөр чанартай, цэнэг хураагуур үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэн явуулдаг хоёр байгууллага юм.

ҮЖ71. Цахилгаан машины цэнэг хураагуур зохион бүтээхийн тулд эдгээр байгууллагууд нь хамтран ажиллах талаархи заавал биелүүлэх хэлцэл (Зэт Хамтын Үйл Ажиллагаа) хийсэн. А ба Б байгууллагууд нь Зэт Хамтын Үйл Ажиллагааг хамтран хянадаг. Энэхүү хэлэлцээр нь УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэх тийм үйл ажиллагаа бүхий хамтын үйл ажиллагаа юм.

ҮЖ72. Хамтын үйл ажиллагаа эрхлэгч нар (А ба Б байгууллагууд) нь М материалыг ашигласнаар цахилгаан машины цэнэг хураагуур зохион бүтээх боломжтой гэж хэдэн жилийн дараа дүгнэсэн. Гэвч М материалын боловсруулалт нь тусгай ноу-хау шаардах бөгөөд М материалыг одоогоор зөвхөн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглаж байна.

ҮЖ73. М материалыг боловсруулах одоо байгаа ноу-хауг ашиглах боломжтой болохын тулд А ба Б байгууллагууд нь өөр нэг хамтын үйл ажиллагаа эрхлэгч байдлаар В байгууллагыг нэгтгэн оруулахаар тохиролцсон. Тус В байгууллага нь Зэт Хамтын Үйл Ажиллагаан дахь хувь оролцоог А ба Б байгууллагуудаас худалдан авч, уг заавал биелүүлэх хэлцлийн нэг оролцогч тал болох юм.

ҮЖ74. В байгууллагын үйл ажиллагаа нь одоогоор зөвхөн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх явдал юм. Уг байгууллага нь М материалыг боловсруулах талаар урт хугацааны, гүнзгий мэдлэгтэй юм.

ҮЖ75. Зэт Хамтын Үйл Ажиллагаан дахь хувь оролцооны хариуд В байгууллага нь А ба Б байгууллагуудад мөнгө төлөх бөгөөд Зэт Хамтын Үйл Ажиллагааны зорилгоор М материалыг боловсруулах өөрийн ноу-хауг ашиглах эрхийг олгох юм. Мөн түүнчлэн, В байгууллага нь М материалыг боловсруулах туршлагатай өөрийн зарим ажилтнуудыг Зэт Хамтын Үйл Ажиллагаанд туслуулан ажиллуулна. Гэвч В байгууллага нь ноу-хаугийн бүх эрхийг өөртөө хадгалж үлдэх учраас уг ноу-хаугийн хяналтыг А ба Б байгууллагууд буюу Зэт Хамтын Үйл Ажиллагаанд шилжүүлэхгүй. Тухайлбал; В байгууллага нь Зэт Хамтын Үйл Ажиллагаан дахь өөрийн оролцоог зогсоовол ямар нэг хязгаарлалт буюу А, Б байгууллагуудад ямар нэгэн нөхөн төлбөр төлөхгүйгээр М материалыг боловсруулах ноу-хауг

## ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР

ашиглах эрхээ буцаан авах, шилжүүлэн ажиллуулж буй ажилтнуудаа эргүүлэн татах эрхтэй.

ҮЖ76. Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшсэн өдрөөрх уг В байгууллагын ноу-хаугийн бодит үнэ цэнэ нь 1,000 ТН байсан. Энэхүү худалдан авалтын яг өмнө, В байгууллагын санхүүгийн тайлан дахь уг ноу-хаугийн дансны үнэ нь 300 ТН байсан.

### Шинжилгээ

ҮЖ77. В байгууллага нь УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэх тийм хамтын үйл ажиллагаа болох Зэт Хамтын Үйл Ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшсэн.

ҮЖ78. Уг хамтын үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцооны худалдан авалтыг тайлагнахдаа В байгууллага нь энэ Стандарт дахь заавар удирдамжтай зөрчилдөхгүй УСНББОУС 40-д болон бусад УСНББОУС-уудад заасан худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн бүх зарчмуудыг даган мөрдөнө (24А параграфыг үзнэ үү). Иймээс В байгууллага нь уг заавал биелүүлэх хэлцлийн үр дүн болох хөрөнгө, өр төлбөрөөс өөрт хамаарах хэсгийг өөрийн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрнө (23-р параграфыг үзнэ үү).

ҮЖ79. В байгууллага нь хамтын үйл ажиллагаа эрхлэгч байдлаар Зэт хамтын үйл ажиллагаанд нэгдэн орсноор М материалыг боловсруулах ноу-хауг ашиглах эрхийг Зэт хамтын үйл ажиллагаанд олгосон. Гэвч В байгууллага нь Зэт Хамтын Үйл Ажиллагаан дахь өөрийн оролцоог зогсоовол ямар нэг хязгаарлалт буюу А, Б байгууллагуудад ямар нэгэн нөхөн төлбөр төлөхгүйгээр М материалыг боловсруулах ноу-хауг ашиглах эрхээ буцаан авах, шилжүүлэн ажиллуулж буй ажилтнуудаа эргүүлэн татах эрхтэй учраас В байгууллага нь энэхүү эрхийн хяналтыг хадгалж үлдэнэ.

ҮЖ80. Иймээс В байгууллага нь М материалыг боловсруулах ноу-хаугийн бүх эрхийг хадгалан үлддэг учраас Зэт хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог худалдан авсны дараа түүнийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Өөрөөр хэлбэл, В байгууллага нь уг ноу-хауг түүний 300 ТН-ийн дансны үнэд үндэслэн хүлээн зөвшөөрсөн хэвээр байна гэсэн үг юм. Хамтын үйл ажиллагаанд олгосон уг ноу-хауг ашиглах эрхийн хяналтыг хадгалан үлдсэний үр дүнд В байгууллага нь тэрхүү ноу-хауг ашиглах эрхийг өөртөө олгож байна. Иймээс В байгууллага нь уг ноу-хауг дахин хэмжихгүй бөгөөд түүнийг ашиглах эрх олголтын хувьд олз, гарзыг хүлээн зөвшөөрөхгүй.



## СТОУС 11-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-ийг СТОУС 11, *Хамтын Хэлэлцээр* (2011 онд гаргасан, үүн дотроо 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан)-ээс үндсэндээ бэлтгэсэн. Энэ Стандартыг гаргах үед УСНББОУСЗ нь СТОУС 9, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийн улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжтой байдлыг харгалзан үзээгүй байсан. Иймээс СТОУС 11 дэх СТОУС 9 гэсэн хэллэгүүдийг санхүүгийн хэрэглүүрүүдийг зохицуулдаг УСНББОУС-уудын нэрээр орлуулан хэрэглэсэн.

УСНББОУС 37 ба СТОУС 11-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 37 нь зарим тохиолдолд СТОУС 11-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 37 дахь “хяналт тавигч байгууллага”, “ашиг, алдагдал” /surplus or deficit/, “хуримтлагдсан ашиг, алдагдал” /accumulated surplus or deficit/ гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. СТОУС 11 дэх адилтгах нэр томъёо нь “толгой компани”, “ашиг, алдагдал” /profit or loss/, “хуримтлагдсан ашиг” /retained earnings/ юм.
- УСНББОУС 35 нь “заавал биелүүлэх хэлцэл” нэр томъёог тодорхойлсон. Энэхүү нэр томъёо нь СТОУС 10-д ашигласан “гэрээний тохиролцоо” нэр томъёоноос илүү өргөн утгатай юм.
- УСНББОУС 37 нь улсын секторын нөхцлийг тусгасан нэмэлт үлгэрчилсэн жишээг агуулсан байдаг.

## УСНББОУС 38–БУСАД БАЙГУУЛЛАГУУД ДАХЬ ХУВЬ ОРОЛЦООНЫ ТОДРУУЛГА

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) 12, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-аас үндсэндээ бэлтгэсэн болно. СТОУС 12-аас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 38–БУСАД БАЙГУУЛЛАГУУД ДАХЬ ХУВЬ ОРОЛЦООНЫ ТОДРУУЛГА

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 38, Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга-ыг 2015 оны 01 дүгээр сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 38-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 38-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
4	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
5	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
6	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
61А	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
61Б	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар

2015 оны 01 дүгээр сар

## УСНББОУС 38–БУСАД БАЙГУУЛЛАГУУД ДАХЬ ХУВЬ ОРОЛЦООНЫ ТОДРУУЛГА

### АГУУЛГА

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-6
Тодорхойлолт	7-8
Заавал биелүүлэх хэлцэл	8
Бусад байгууллагууд дахь хувь оролцооны талаархи мэдээллийг тодруулах	9-11
Гол шүүн тунгаалт ба таамаглалууд	12-14
Хөрөнгө оруулалтын байгууллагын статус	15-16
Хяналтанд буй байгууллагууд дахь хувь оролцоо	17-26
Эдийн засгийн нэгдмэл байгууллагын үйл ажиллагаа болон мөнгөн гүйлгээнд хяналтын бус оролцоотой байх хувь оролцоо	19
Мэдэгдэхүйц хязгаарлалтын шинж төрөл ба хэмжээ	20
Нэгтгэсэн, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь уг байгууллагын хувь оролцоотой холбоотой эрсдлийн шинж төрөл	21-24
Хяналтанд буй байгууллага дахь уг хяналт тавигч байгууллагын өмчлөлийн хувь оролцооны, хяналтаа алдахад хүргэхгүй өөрчлөлтийн үр дагавар	25
Хяналтанд буй байгууллага дахь хяналтыг тухайн тайлант үед алдсаны үр дагавар	26
Нэгтгэдэггүй, хяналтанд буй байгууллагууд (Хөрөнгө оруулалтын байгууллагууд) дахь хувь оролцоо	27-34
Хамтын хэлэлцээр болон хараат байгууллага дахь хувь оролцоо	35-39
Хамтын хэлэлцээр болон хараат байгууллага дахь уг байгууллагын хувь оролцооны шинж төрөл, хэмжээ, санхүүгийн үр нөлөө	36-38
Хамтын хэлэлцээр болон хараат байгууллага дахь уг байгууллагын хувь оролцоотой холбоотой эрсдэл	39
Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь хувь оролцоо	40-48
Хувь оролцооны шинж төрөл	43-45
Эрсдлийн шинж төрөл	46-48
Тоогоор илэрхийлэх боломжгүй өмчлөлийн хувь оролцоо	49-50
Худалдан борлуулах зорилгоор олж эзэмшсэн хяналтын хувь оролцоо	51-57
Шилжилтийн нөхцөл	58-60
Хүчин төгөлдөр болох хугацаа	61-62
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
СТОУС 12-той харьцуулалт	

## БУСАД БАЙГУУЛЛАГУУД ДАХЬ ХУВЬ ОРОЛЦООНЫ ТОДРУУЛГА

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-ыг 1-62-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 38-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь дараах зүйлсийг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулахыг байгууллагаас шаардахад оршино:
  - (а) Хяналтанд буй байгууллагууд, нэгтгэдэггүй хяналтанд буй байгууллагууд, хамтын хэлэлцээр, хараат байгууллага, нэгтгэдэггүй тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь өөрийн хувь оролцооны шинж төрөл ба холбогдох эрсдэл; ба
  - (б) Өөрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд тэдгээр хувь оролцооны үзүүлэх нөлөө.

## Цар хүрээ

2. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь хяналтанд буй байгууллагууд, нэгтгэдэггүй хяналтанд буй байгууллагууд, хамтын хэлэлцээр болон хараат байгууллага, нэгтгэдэггүй тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь өөрийн хувь оролцооны талаархи мэдээллийг тодруулахдаа энэхүү Стандартыг мөрдөнө.
3. Дараах зүйлсийн аль нэгэнд хувь оролцоотой байгууллага нь энэ Стандартыг мөрдөнө:
  - (а) Хяналтанд буй байгууллагууд;
  - (б) Хамтын хэлэлцээр (өөрөөр хэлбэл, хамтын үйл ажиллагаа эсвэл хамтарсан үйлдвэр);
  - (в) Хараат байгууллага; эсвэл
  - (г) Нэгтгэдэггүй тусгай бүтэц бүхий байгууллагууд.
4. Энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөхгүй:
  - (а) УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг мөрддөг, ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр буюу ажилтны бусад урт хугацаат тэтгэмжийн хөтөлбөр.
  - (б) УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*-г мөрддөг, байгууллагын тусдаа санхүүгийн тайлан. Гэвч:
    - (i) Хэрэв байгууллага нь нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагуудад хувь оролцоотой бөгөөд өөрийн цорын ганц санхүүгийн тайлан болгон тусдаа санхүүгийн тайланг бэлтгэдэг бол тухайн байгууллага нь тэрхүү тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ 40-48-р параграфын шаардлагуудыг мөрдөнө.
    - (ii) Өөрийн хяналтанд буй бүх байгууллагуудыг УСНББОУС 35-ын 56-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан

бодит үнэ цэнээр хэмжиж, тусгадаг тийм санхүүгийн тайланг бэлтгэдэг хөрөнгө оруулалтын байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагуудтай холбоотойгоор энэ Стандартаар шаардсан тодруулгыг толилуулна.

- (в) Хамтын хэлэлцээрт оролцдог боловч хамтын хяналт тавьдаггүй байгууллагын эзэмшиж буй хувь оролцоо нь уг хэлэлцээрт мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үр дүнтэй, эсвэл тусгай бүтэц бүхий байгууллага дахь хувь оролцоо байхаас бусад тохиолдолд тэрхүү байгууллагын эзэмшиж буй хувь оролцоо.
- (г) УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн дагуу тайлагнадаг, өөр байгууллага дахь хувь оролцоо. Гэвч байгууллага нь доорх тохиолдолд энэ Стандартыг мөрдөнө:
- (i) Уг хувь оролцоо нь УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг, хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо байх тохиолдолд; эсвэл
- (ii) Уг хувь оролцоо нь нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллага дахь хувь оролцоо байх тохиолдолд.

5. [Хассан]

6. [Хассан]

## Тодорхойлолт

7. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Заавал биелүүлэх хэлцэл:** Энэ Стандартын зорилгын хувьд заавал биелүүлэх хэлцэл нь хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адил хууль ёсны хүчин төгөлдөр эрх, үүргийг бий болгодог хэлцэл юм. Энэ нь гэрээгээр үүссэн эрх болон бусад хууль ёсны эрхийг агуулсан байдаг.

Энэ Стандартын зорилгын хувьд, **Бусад байгууллага дахь хувь оролцоо** гэдэг нь уг бусад байгууллагын үр дүнгээс үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд тухайн байгууллагад эрсдэл учруулах заавал биелүүлэх хэлцлээр буюу өөр бусад байдлаар хийгдэх оролцоог илэрхийлнэ. Бусад байгууллага дахь хувь оролцоог өмчийн буюу өрийн хэрэглүүрийн эзэмшилт, түүнчлэн санхүүжилт, төлбөрийн чадварын дэмжлэг, зээлийн сайжруулалт, хөрөнгийн баталгаа олголт гэх мэт бусад хэлбэрийн оролцоогоор нотолж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй. Энэ нь бусад байгууллагыг хянах, хамтран хянах эсвэл мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх уг байгууллагын арга хэрэгслийг агуулсан байдаг. Харин байгууллага нь

санхүүжүүлэгч/санхүүжигч эсвэл худалдан авагч/нийлүүлэгчийн зөвхөн нийтлэг харилцаатай байснаар уг бусад байгууллагад заавал хувь оролцоотой гэсэн үг биш юм.

Бусад байгууллагууд дахь хувь оролцооны талаархи нэмэлт мэдээллийг МЗУ7-МЗУ9-р параграфт тусгасан.

Өгөөжийн хувьсан өөрчлөлтийг УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-гийн МЗУ57-МЗУ59-р параграфт тайлбарласан болно.

Энэ Стандартын зорилгын хувьд Тусгай бүтэц бүхий байгууллагаас олсон орлогод дараах орлого хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд: тогтмол болон тогтмол бус хураамж, хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, тусгай бүтэц бүхий байгууллага дахь хувь оролцоог дахин хэмжих буюу үл хүлээн зөвшөөрснөөс үүссэн олз буюу гарз, уг тусгай бүтэц бүхий байгууллагад хөрөнгө, өр төлбөрийг шилжүүлснээс үүссэн олз, гарз.

Тусгай бүтэц бүхий байгууллага гэдэг нь:

- (а) Байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд захиргааны зохицуулалт буюу хууль тогтоомж нь ихэвчлэн голлох хүчин зүйл болдог байгууллагуудын хувьд тухайн байгууллагын хяналтыг тодорхойлоход заавал биелүүлэх хэлцэл чухал ач холбогдолтой бөгөөд холбогдох үйл ажиллагааг заавал биелүүлэх хэлцлийн арга замаар удирдан чиглүүлэх гэх мэтээр тэрхүү байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд уг захиргааны зохицуулалт буюу хууль тогтоомж нь голлох хүчин зүйл биш байхаар зохион байгуулсан байгууллага; эсвэл
- (б) Байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд саналын буюу адилтгах эрх нь ихэвчлэн голлох хүчин зүйл болдог байгууллагуудын хувьд аливаа саналын эрх нь зөвхөн захиргааны ажил үүрэгтэй холбоотой бөгөөд холбогдох үйл ажиллагааг заавал биелүүлэх хэлцлийн арга замаар удирдан чиглүүлдэг гэх мэтээр тэрхүү байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд уг саналын буюу адилтгах эрх нь голлох хүчин зүйл биш байхаар зохион байгуулсан байгууллага.

Тусгай бүтэц бүхий байгууллагуудын талаархи нэмэлт мэдээллийг МЗУ20-МЗУ23-р параграфт тусгасан.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно. Дараах нэр томъёог УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*, УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-т



тодорхойлсон. Үүнд: хараат байгууллага, нэгтгэсэн санхүүгийн тайлан, хяналт, хяналтанд буй байгууллага, хяналт тавигч байгууллага, эдийн засгийн нэгдмэл байгууллага, өмчийн арга, хөрөнгө оруулалтын байгууллага, хамтын хэлэлцээр, хамын хяналт, хамтын үйл ажиллагаа, хамтарсан үйлдвэр, хяналтын бус хувь оролцоо, холбогдох үйл ажиллагаа, тусдаа санхүүгийн тайлан, тусдаа бүтэц, мэдэгдэхүйц нөлөө.

### **Заавал биелүүлэх хэлцэл**

8. Заавал биелүүлэх хэлцлийг хэд хэдэн арга замаар нотлон харуулж болно. Заавал биелүүлэх хэлцлийг байнга биш боловч ихэвчлэн бичгээр үйлдэх бөгөөд талуудын хоорондох гэрээ эсвэл баримтжуулсан тохиролцоо хэлбэртэй байдаг. Хууль тогтоох эсвэл засаглах бүрэн эрх гэх мэт хуулиар тогтоосон механизм нь гэрээний тохиролцоотой адилаар хуулийн дагуу хүчин төгөлдөр болох хэлцлийг дангаараа, эсвэл талуудын хоорондох гэрээтэй холбоотойгоор мөн үүсгэн бий болгодог.

### **Бусад байгууллагууд дахь хувь оролцооны талаархи мэдээллийг тодруулах**

9. 1-р параграфт дурдсан зорилгыг биелүүлэхийн тулд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (a) Доорх зүйлсийг тодорхойлохын тулд хийсэн гол шүүн тунгаалт ба таамаглалууд:
    - (i) Өөр байгууллага буюу хэлэлцээр дэх өөрийн хувь оролцооны шинж төрөл;
    - (ii) Өөрөө хувь оролцоотой байгаа хамтын хэлэлцээрийн төрөл (12-14-р параграф);
    - (iii) Хэрэв хамааралтай бол хөрөнгө оруулалтын байгууллагын тодорхойлолтыг өөрөө хангаж буй эсэх (15-р параграф); ба
  - (б) Доорх зүйлс дэх өөрийн хувь оролцооны талаархи мэдээлэл:
    - (i) Хяналтанд буй байгууллага (17-26-р параграф);
    - (ii) Хамтын хэлэлцээр ба хараат байгууллага (35-39-р параграф);
    - (iii) Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд (40-48-р параграф);
    - (iv) Тоогоор илэрхийлэх боломжгүй өмчлөлийн хувь оролцоо (49-50-р параграф); ба
    - (v) Худалдан борлуулах зорилгоор олж эзэмшсэн хяналтын хувь оролцоо (51-57-р параграф).
10. Бусад УСНББОУС-аар шаардсан тодруулгуудын хамтаар энэ Стандартаар шаардсан тодруулга нь 1-р параграфт дурдсан зорилгыг

ханган биелүүлэхгүй бол байгууллага нь уг зорилгыг биелүүлэхэд шаардлагатай аливаа нэмэлт мэдээллийг тодруулна.

11. Байгууллага нь уг тодруулгын зорилгыг хангахад шаардлагатай дэлгэрэнгүй байдлын түвшин болон энэ Стандартад заасан шаардлага нэг бүрд хэр их ач холбогдол өгөх эсэхээ харгалзан үзнэ. Байгууллага нь хангалттай дэлгэрэнгүй бус том дүнд багтаан оруулснаар эсвэл өөр өөр шинж чанар бүхий зүйлсийг нэгтгэн нийлүүлснээр чухал мэдээллийг бүрхэгдүүлэхгүйн тулд тодруулгыг нэгтгэн нийлүүлж эсвэл салган зааглаж харуулна (МЗУ2-МЗУ6-р параграфыг үзнэ үү).

### Гол шүүн тунгаалт ба таамаглалууд

12. Байгууллага нь дараах зүйлсийг тодорхойлоход ашигласан арга зүйг тодруулна:
- (a) Тухайн байгууллага нь УСНББОУС 35-ын 18 ба 20-р параграфт заасанчлан, бусад байгууллагыг хянадаг эсэх;
  - (б) Тухайн байгууллага нь хэлэлцээрт хамтын хяналттай эсвэл өөр байгууллагад мэдэгдэхүйц нөлөөтэй эсэх; ба
  - (в) Хэлэлцээрийг тусдаа бүтцээр дамжуулан зохион байгуулсан тохиолдолд уг хамтын хэлэлцээрийн төрөл (өөрөөр хэлбэл, хамтын үйл ажиллагаа эсвэл хамтарсан үйлдвэр).
13. 12-р параграфтаар шаардсан тодруулгыг санхүүгийн тайланд харуулна эсвэл санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тэрхүү санхүүгийн тайлантай адил нөхцлөөр, ижил хугацаанд хүргэн танилцуулах боломжтой бусад зарим тайланд тухайн санхүүгийн тайлангаас харилцан лавлагаа үүсгэснээр толилуулна. Харилцан лавлагаа үүсгэснээр уг мэдээллийг тусгаагүй бол тухайн санхүүгийн тайлан нь иж бүрэн бус болно. Ийм харилцан лавлагаа ашиглахыг улс орнууд хязгаарлан хориглодог байж болно.
14. 12-р параграфыг даган мөрдөхийн тулд байгууллага нь тухайлбал, дараах зүйлсийг тодорхойлохдоо харгалзан үзсэн хүчин зүйлсийг тодруулна:
- (a) Бусад байгууллага дахь хувь оролцоо нь өмчийн эсвэл өрийн хэрэглүүрийн эзэмшилтээр нотлогдохгүй тохиолдолд тухайн байгууллага нь уг тодорхой нэг байгууллагыг (эсвэл байгууллагуудын ижил төсөөтэй ангийг) хянадаг эсэх;
  - (б) Хэдийгээр тухайн байгууллага нь өөр байгууллагын (буюу байгууллагуудын ангийн) саналын эрхийн тэн хагасаас илүүг эзэмшдэг боловч уг өөр байгууллагыг хянадаггүй эсэх.
  - (в) Хэдийгээр тухайн байгууллага нь өөр байгууллагын (эсвэл байгууллагуудын ангийн) саналын эрхийн тэн хагасаас бага

хэсгийг эзэмшдэг боловч уг өөр байгууллага (эсвэл байгууллагууд)-ыг хянадаг эсэх;

- (г) Тухайн байгууллага нь төлөөлөн оролцогч эсвэл үндсэн оролцогч эсэх (УСНББОУС 35-ын МЗУ60-МЗУ74-р параграфыг үзнэ үү);
- (д) Хэдийгээр тухайн байгууллага нь өөр байгууллагын саналын эрхийн 20 хувь буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг боловч уг өөр байгууллагад мэдэгдэхүйц нөлөөгүй эсэх.
- (е) Хэдийгээр тухайн байгууллага нь өөр байгууллагын саналын эрхийн 20 хувиас бага хэсгийг эзэмшдэг боловч уг өөр байгууллагад мэдэгдэхүйц нөлөөтэй эсэх.

### **Хөрөнгө оруулалтын байгууллагын статус**

- 15. Хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 35-д заасанчлан, өөрийгөө хөрөнгө оруулалтын байгууллага гэж тодорхойлсон тохиолдолд уг хөрөнгө оруулалтын байгууллага нь өөрийгөө хөрөнгө оруулалтын байгууллага гэж тодорхойлохын тулд хийсэн гол шүүн тунгаалт ба таамаглалуудын талаархи мэдээллийг тодруулна. Хөрөнгө оруулалтын байгууллага нь УСНББОУС 35-ын 61-р параграфт заасан бүх шинжүүдтэй бол энэхүү мэдээллийг тодруулах шаардлагагүй юм.
- 16. Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага болсон эсвэл ийм байхаа больсон тохиолдолд тухайн байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагын статусын өөрчлөлт ба ийм өөрчлөлтийн шалтгааныг тодруулна. Түүнчлэн, хөрөнгө оруулалтын байгууллага болсон уг байгууллага нь тухайн толилуулсан тайлант үеийн санхүүгийн тайланд тэрхүү статусын өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөөг, үүн дотроо дараах зүйлсийг тодруулна.
  - (а) Нэгтгэхээ больсон хяналтанд буй байгууллагуудын тэрхүү статусын өөрчлөлтийн өдрөөрх нийт бодит үнэ цэнэ;
  - (б) Хэрэв байгаа бол УСНББОУС 35-ын 64-р параграфын дагуу тооцоолсон нийт олз буюу гарз; ба
  - (в) Уг олз, гарзыг (хэрэв тусад нь толилуулаагүй бол) хүлээн зөвшөөрсөн ашиг, алдагдлын мөрийн зүйл (зүйлс).

### **Хяналтанд буй байгууллагууд дахь хувь оролцоо**

- 17. Байгууллага нь өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд дараах боломжийг олгох мэдээллийг тодруулна:
  - (а) Доорх зүйлсийг ойлгох:
    - (i) Эдийн засгийн нэгдмэл байгууллагын бүтэц бүрэлдэхүүн; ба

- (ii) Эдийн засгийн нэгдмэл байгууллагын үйл ажиллагаа болон мөнгөн гүйлгээнд хяналтын бус оролцоотой байх хувь оролцоо (19-р параграф); ба
  - (б) Доорх зүйлсийг үнэлэх:
    - (i) Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хөрөнгөнд хандан нэвтрэх буюу ашиглах ба өр төлбөрийг барагдуулах түүний чадвар, боломжинд тавигдах мэдэгдэхүйц хязгаарлалтын шинж төрөл, хэмжээ (20-р параграф);
    - (ii) Нэгтгэсэн, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь тухайн байгууллагын хувь оролцоотой холбоотой эрсдлийн шинж төрөл ба эрсдлийн өөрчлөлт (21-24-р параграф);
    - (iii) Хяналтанд буй байгууллага дахь уг байгууллагын өмчлөлийн хувь оролцооны, хяналтаа алдахад хүргэхгүй өөрчлөлтийн үр дагавар (25-р параграф); ба
    - (iv) Хяналтанд буй байгууллага дахь хяналтыг тухайн тайлант үеийн туршид алдсаны үр дагавар (26-р параграф).
  - 18. Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхэд ашигласан хяналтанд буй байгууллагын санхүүгийн тайлангийн өдөр эсвэл тайлант хугацаа нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдөр эсвэл тайлант хугацаанаас өөр байх тохиолдолд (УСНББОУС 35-ын 46-р параграфыг үзнэ үү) байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
    - (a) Хяналтанд буй байгууллагын санхүүгийн тайлангийн тайлант хугацааны эцсийн өдөр; ба
    - (б) Өөр өдөр эсвэл тайлант хугацааг ашигласан шалтгаан.
- Эдийн засгийн нэгдмэл байгууллагын үйл ажиллагаа болон мөнгөн гүйлгээнд хяналтын бус оролцоотой байх хувь оролцоо
- 19. Уг тайлагнагч байгууллагын хувьд материаллаг дүнтэй, хяналтын бус оролцоо бүхий өөрийн хяналтанд буй байгууллага тус бүрийн хувьд тухайн байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
    - (a) Тухайн хяналтанд буй байгууллагын нэр;
    - (б) Тухайн хяналтанд буй байгууллагын оршин суугаа хаяг ба хуулийн хэлбэр, түүний үйл ажиллагаагаа явуулдаг улс орон;
    - (в) Хяналтын бус хувь оролцоогоор эзэмшиж буй өмчлөлийн хувь оролцооны хэмжээ;
    - (г) Хэрэв эзэмшиж буй өмчлөлийн хувь оролцооны хэмжээнээс өөр бол уг хяналтын бус хувь оролцоогоор эзэмшиж буй саналын эрхийн хувь хэмжээ;
    - (д) Уг хяналтанд буй байгууллагын хяналтын бус хувь оролцоонд тухайн тайлант үед хуваарилсан ашиг, алдагдал;

- (е) Тухайн тайлант үеийн эцэст уг хяналтанд буй байгууллагын хуримтлагдсан хяналтын бус хувь оролцоо; ба
- (ж) Тухайн хяналтанд буй байгууллагын талаархи хураангуй санхүүгийн мэдээлэл (МЗУ10-р параграфыг үзнэ үү).

**Мэдэгдэхүйц хязгаарлалтын шинж төрөл ба хэмжээ**

20. **Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**

- (а) Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хөрөнгөнд хандан нэвтрэх буюу ашиглах ба өр төлбөрийг барагдуулах түүний чадвар, боломжинд тавигдах заавал биелүүлэх хэлцлийн дараах гэх мэт мэдэгдэхүйц хязгаарлалтууд (жишээлбэл: хуулийн, гэрээний, зохицуулалтын хязгаарлалтууд):
  - (i) Хяналт тавигч байгууллага буюу түүний хяналтанд буй байгууллагууд нь уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын бусад байгууллагуудад мөнгө болон бусад хөрөнгийг шилжүүлэн өгөх эсвэл тэднээс шилжүүлэн авах чадвар, боломжийг хязгаарласан хязгаарлалтууд.
  - (ii) Эдийн засгийн нэгдмэл байгууллагын бусад байгууллагуудад ногдол ашиг ба капиталын бусад хуваарилалт хийх, тэдгээр бусад байгууллагуудад зээл олгох буюу тэднээс зээл авахыг хязгаарлаж болох баталгаа буюу бусад шаардлагууд.
- (б) Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хөрөнгөнд хандан нэвтрэх буюу ашиглах ба өр төлбөрийг барагдуулах тухайн байгууллагын чадвар, боломжийг мэдэгдэхүйц хязгаарлаж чадах (хяналт тавигч байгууллага нь өөрийн өр төлбөрийг барагдуулахаас өмнө уг хяналтанд буй байгууллагын өр төлбөрийг барагдуулах үүрэгтэй, эсвэл хяналтанд буй байгууллагын хөрөнгөнд хандан нэвтрэх буюу ашиглах, өр төлбөрийг барагдуулахын тулд хяналтын бус хувь оролцооны зөвшөөрлийг авах шаардлагатай гэх мэт тохиолдол) хяналтын бус оролцооны хамгаалалтын эрхийн шинж төрөл, хэмжээ.
- (в) Эдгээр хязгаарлалтуудыг мөрдөх хөрөнгө, өр төлбөрийн тухайн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дансны үнэ.

**Нэгтгэсэн, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь уг байгууллагын хувь оролцоотой холбоотой эрсдлийн шинж төрөл**

21. Байгууллага нь нэгтгэсэн, тусгай бүтэц бүхий байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг хяналт тавигч байгууллага буюу түүний хяналтанд буй байгууллагуудаас шаардах аливаа заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүд, үүн дотроо тухайн тайлагнагч байгууллагад алдагдал учруулж болох үйл явдал буюу нөхцөл байдлуудыг (жишээлбэл; уг тусгай бүтэц бүхий байгууллагын хөрөнгийг худалдан авах эсвэл түүнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх

үүрэгтэй холбоотой, төлбөрийн чадварын хэлэлцээр болон зээлийн зэрэглэл тогтоох арга механизмыг) тодруулна.

22. Хяналт тавигч байгууллага буюу түүний хяналтанд буй байгууллагууд нь ийм гэрээний үүрэггүй боловч уг нэгтгэсэн, тусгай бүтэц бүхий байгууллагад тухайн тайлант үед санхүүгийн буюу бусад дэмжлэг үзүүлсэн (жишээлбэл; уг тусгай бүтэц бүхий байгууллагын хөрөнгийг эсвэл түүний гаргасан хэрэглүүрийг худалдан авах) бол тэрхүү байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Үзүүлсэн дэмжлэгийн төрөл ба дүн, үүн дотроо, хяналт тавигч байгууллага буюу түүний хяналтанд буй байгууллагууд нь санхүүгийн дэмжлэгийг олж авахад уг тусгай бүтэц бүхий байгууллагад туслалцаа үзүүлсэн нөхцөл байдал; ба
  - (б) Дэмжлэг үзүүлсэн шалтгаан.
23. Хяналт тавигч байгууллага буюу түүний аль нэг хяналтанд буй байгууллага нь хэдийгээр заавал биелүүлэх хэлцлийн дагуу ийм үүрэг хүлээгээгүй боловч тэрхүү өмнө нь нэгтгэдэггүй байсан, тусгай бүтэц бүхий байгууллагад тухайн тайлант үед санхүүгийн буюу бусад дэмжлэг үзүүлсэн бөгөөд ингэж дэмжлэг үзүүлснээр тусгай бүтэц бүхий байгууллагыг тухайн байгууллага хяналтандаа авахад хүргэсэн бол уг байгууллага нь ийм шийдвэр гаргахад хүргэсэн холбогдох хүчин зүйлсийн талаархи тайлбарыг тодруулна.
24. Байгууллага нь нэгтгэсэн, тусгай бүтэц бүхий байгууллагад санхүүгийн буюу бусад дэмжлэг үзүүлэх одоогийн аливаа сэдэл төлөвлөгөө, үүн дотроо санхүүгийн дэмжлэгийг олж авахад уг тусгай бүтэц бүхий байгууллагад туслах сэдэл төлөвлөгөөгөө тодруулна.

Хяналтанд буй байгууллага дахь уг хяналт тавигч байгууллагын өмчлөлийн хувь оролцооны, хяналтаа алдахад хүргэхгүй өөрчлөлтийн үр дагавар

25. Байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь түүний өмчлөлийн хувь оролцооны, хяналтаа алдахад хүргэхгүй аливаа өөрчлөлтийн тэрхүү хяналт тавигч байгууллагын эздэд хамаарах цэвэр хөрөнгө/өмчид үзүүлэх үр дагаврыг харуулсан хүснэгт хөтөлбөрийг толилуулна.

Хяналтанд буй байгууллага дахь хяналтыг тухайн тайлант үед алдсаны үр дагавар

26. Байгууллага нь хэрэв байгаа бол УСНББОУС 35-ын 52-р параграфын дагуу тооцоолсон олз, гарз болон дараах зүйлсийг тодруулна:
- (а) Өмнө нь хяналтанд байсан байгууллагад хадгалан үлдсэн аливаа хөрөнгө оруулалтыг тэрхүү хяналтаа алдсан өдрөөрх түүний бодит үнэ цэнээр хэмжихэд хамаарах уг олз, гарзын хэсэг; ба

- (б) Уг олз, гарзыг (хэрэв тусад нь толилуулаагүй бол) хүлээн зөвшөөрсөн ашиг, алдагдлын мөрийн зүйл (зүйлс).

**Нэгтгэдэггүй, хяналтанд буй байгууллагууд (Хөрөнгө оруулалтын байгууллагууд) дахь хувь оролцоо**

27. УСНББОУС 35-ын дагуу нэгтгэлээс чөлөөлөгдөх заалтыг мөрдөх ба харин хяналтанд буй байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тайлагнах шаардлагатай, хөрөнгө оруулалтын байгууллага нь энэ тухай тодруулга хийнэ.
28. Хөрөнгө оруулалтын байгууллага нь нэгтгэдэггүй хяналтанд буй байгууллага тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:
- (а) Тухайн хяналтанд буй байгууллагын нэр;
  - (б) Тухайн хяналтанд буй байгууллагын оршин суугаа хаяг ба хуулийн хэлбэр, түүний үйл ажиллагаагаа явуулдаг улс орон;
  - (в) Уг хөрөнгө оруулалтын байгууллагын эзэмшиж буй өмчлөлийн хувь оролцооны хэмжээ, түүнчлэн хэрэв өөр бол эзэмшиж буй саналын эрхийн хувь хэмжээ;
29. Хэрэв хөрөнгө оруулалтын байгууллага нь өөр хөрөнгө оруулалтын байгууллагад хяналт тавигч байгууллага бол тухайн хяналт тавигч байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтын байгууллагын хяналтанд буй байгууллагын хянаж байгаа хөрөнгө оруулалтуудын хувьд 28(а)-(в) параграфт дурдсан тодруулгыг бас бэлтгэнэ. Дээрх мэдээллийг агуулсан хяналтанд буй байгууллага (байгууллагууд)-ын санхүүгийн тайланг уг хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайланд тусган оруулснаар ийм тодруулгыг хийж болно.
30. Хөрөнгө оруулалтын байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Нэгтгэдэггүй хяналтанд буй байгууллага нь мөнгөн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт хэлбэрээр хөрөнгө оруулалтын байгууллагад мөнгө санг шилжүүлэх, эсвэл түүнд уг хөрөнгө оруулалтын байгууллагаас олгосон зээл буюу урьдчилгааг буцаан төлөх тухайн нэгтгэдэггүй хяналтанд буй байгууллагын чадвар, боломжинд заавал биелүүлэх хэлцлийн дагуу тавигдах аливаа мэдэгдэхүйц хязгаарлалтын (жишээлбэл; зээллэгийн хэлэлцээр, зохицуулалтын шаардлагууд болон гэрээт хэлэлцээрийн үр дүнд) шинж төрөл ба хэмжээ;
  - (б) Нэгтгэдэггүй хяналтанд буй байгууллагад санхүүгийн буюу бусад дэмжлэг үзүүлэх одоогийн аливаа баталгаа буюу сэдэл төлөвлөгөө, үүн дотроо санхүүгийн дэмжлэг олж авахад уг хяналтанд буй байгууллагад туслах баталгаа буюу сэдэл төлөвлөгөө.

31. Хөрөнгө оруулалтын байгууллага буюу түүний аль нэг хяналтанд буй байгууллага нь хэдийгээр заавал биелүүлэх хэлцлийн дагуу ийм үүрэг хүлээгээгүй боловч тэрхүү нэгтгэдэггүй хяналтанд буй байгууллагад тухайн тайлант үед санхүүгийн буюу бусад дэмжлэг үзүүлсэн (жишээлбэл; уг хяналтанд буй байгууллагын хөрөнгийг эсвэл түүний гаргасан хэрэглүүрийг худалдан авах, санхүүгийн дэмжлэг олж авахад хяналтанд буй байгууллагад туслах) бол тэрхүү байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Нэгтгэдэггүй хяналтанд буй байгууллага бүрд үзүүлсэн дэмжлэгийн төрөл ба дүн; ба
  - (б) Дэмжлэг үзүүлсэн шалтгаан.
32. Хөрөнгө оруулалтын байгууллага нь нэгтгэдэггүй, хяналтанд буй, тусгай бүтэц бүхий байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг уг байгууллага буюу түүний нэгтгэдэггүй, хяналтанд буй байгууллагуудаас шаардах аливаа заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүдийг, үүн дотроо тухайн тайлагнагч байгууллагад алдагдал учруулж болох үйл явдал буюу нөхцөл байдлуудыг (жишээлбэл; уг тусгай бүтэц бүхий байгууллагын хөрөнгийг худалдан авах эсвэл түүнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй холбоотой, төлбөрийн чадварын хэлэлцээр болон зээлийн зэрэглэл тогтоох арга механизмыг) тодруулна.
33. Хөрөнгө оруулалтын байгууллага буюу түүний нэгтгэдэггүй аль нэг хяналтанд буй байгууллага нь хэдийгээр заавал биелүүлэх хэлцлийн дагуу ийм үүрэггүй боловч тэрхүү хөрөнгө оруулалтын байгууллагын хянадаггүй байсан, уг нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагад тайлант үед санхүүгийн буюу бусад дэмжлэг үзүүлсэн бөгөөд ингэж дэмжлэг үзүүлснээр тусгай бүтэц бүхий байгууллагыг тухайн хөрөнгө оруулалтын байгууллага хяналтандаа авахад хүргэсэн бол хөрөнгө оруулалтын байгууллага нь ийм дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргахад хүргэсэн холбогдох хүчин зүйлсийн талаархи тайлбарыг тодруулна.
34. Хөрөнгө оруулалтын байгууллагыг хянадаг боловч өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш хяналт тавигч байгууллага нь ийм нэгтгэдэггүй хяналтанд буй байгууллагуудын хувьд 27-33-р параграфтаар шаардсан мэдээллийг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа тодруулна.

### **Хамтын хэлэлцээр болон хараат байгууллага дахь хувь оролцоо**

35. Байгууллага нь дараах зүйлсийг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна:
- (а) Хамтын хэлэлцээр болон хараат байгууллага дахь өөрийн хувь оролцооны шинж төрөл, хэмжээ, санхүүгийн үр нөлөө, үүн дотроо, тухайн хамтын хэлэлцээр болон хараат байгууллагад



хамтын хяналттай эсвэл мэдэгдэхүйц нөлөөтэй бусад хөрөнгө оруулагчидтай холбогдох түүний харилцааны шинж төрөл ба үр нөлөө (36, 38-р параграф);

- (б) Хамтарсан үйлдвэр болон хараат байгууллага дахь түүний хувь оролцоотой холбоотой эрсдлийн шинж төрөл ба эрсдлийн өөрчлөлт (39-р параграф).

Хамтын хэлэлцээр болон хараат байгууллага дахь уг байгууллагын хувь оролцооны шинж төрөл, хэмжээ, санхүүгийн үр нөлөө

36. Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Уг тайлагнагч байгууллагын хувьд материаллаг байх, хамтын хэлэлцээр болон хараат байгууллага тус бүрийн хувьд:
- (i) Хамтын хэлэлцээр буюу хараат байгууллагын нэр;
  - (ii) Хамтын хэлэлцээр буюу хараат байгууллагатай уг байгууллагын холбогдох харилцааны шинж төрөл (жишээлбэл; хамтын хэлэлцээр буюу хараат байгууллагын үйл ажиллагааны шинж төрөл ба тэдгээр нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд стратегийн ач холбогдолтой эсэхийг тайлбарлан тодорхойлох);
  - (iii) Тухайн хамтын хэлэлцээр буюу хараат байгууллагын оршин суугаа хаяг ба хуулийн хэлбэр, түүний үйл ажиллагаагаа явуулдаг улс орон; ба
  - (iv) Уг байгууллагын эзэмшиж буй өмчлөлийн буюу оролцооны хувь хэмжээ, түүнчлэн хэрэв өөр бол эзэмшиж буй саналын эрхийн хувь хэмжээ;
- (б) Уг тайлагнагч байгууллагын хувьд материаллаг байх, хамтарсан үйлдвэр болон хараат байгууллага тус бүрийн хувьд:
- (i) Хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг өмчийн арга ашиглаж, эсвэл бодит үнэ цэнээр хэмждэг эсэх;
  - (ii) МЗУ12, МЗУ13-р параграфт тусгайлан заасанчлан, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагын талаархи хураангуй санхүүгийн мэдээлэл; ба
  - (iii) Хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагыг өмчийн арга ашиглан тайлагнадаг тохиолдолд уг хөрөнгө оруулалтанд хамаарах жишиг зах зээлийн үнэ байгаа бол тухайн хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь түүний хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ.
- (в) Бие даасан байдлаараа материаллаг бус, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь уг байгууллагын хөрөнгө оруулалтын талаархи МЗУ16-р параграфт тусгайлан заасан санхүүгийн мэдээлэл:

- (i) **Бие даасан байдлаараа материаллаг бус бүх хамтарсан үйлдвэрүүдийг нэгтгэн нийлүүлснээр; ба**
  - (ii) **Бие даасан байдлаараа материаллаг бус бүх хараат байгууллагуудыг нэгтгэн нийлүүлснээр. Нэгтгэн нийлүүлсэн энэхүү мэдээллийг хамтарсан үйлдвэрийн хувьд нэгтгэсэн мэдээллээс тусад нь тодруулна.**
37. Хөрөнгө оруулалтын байгууллага нь 36(б)-36(в) параграфтаар шаардсан тодруулгыг хийх шаардлагагүй юм.
38. **Байгууллага нь мөн дараах зүйлсийг тодруулна:**
- (a) **Хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага нь мөнгөн ногдол ашиг болон түүнтэй адилтгах хуваарилалт хэлбэрээр тухайн байгууллагад мөнгө санг шилжүүлэх эсвэл түүнд уг байгууллагаас олгосон зээл, урьдчилгааг буцаан төлөх тэрхүү хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагын чадвар, боломжинд тавигдах аливаа мэдэгдэхүйц хязгаарлалтын (жишээлбэл; зээллэгийн хэлэлцээр, зохицуулалтын шаардлагууд болон хамтарсан үйлдвэр, хараат байгууллагыг хамтран хянадаг эсвэл мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг хөрөнгө оруулагчдын хоорондох заавал биелүүлэх хэлцлийн үр дүнд) шинж төрөл ба хэмжээ.**
  - (б) **Өмчийн аргыг хэрэглэхдээ ашигласан, хамтарсан үйлдвэрийн болон хараат байгууллагын санхүүгийн тайлангийн өдөр буюу тайлант хугацаа нь уг байгууллагын санхүүгийн тайлангийн өдөр буюу тайлант хугацаанаас өөр байх тохиолдолд:**
    - (i) **Тухайн хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагын санхүүгийн тайлангийн тайлант хугацааны эцсийн өдөр; ба**
    - (ii) **Өөр өдөр буюу тайлант хугацааг ашигласан шалтгаан.**
  - (в) **Өмчийн арга хэрэглэснээр, байгууллага нь хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагын алдагдлаас өөрт ногдох хэсгийг хүлээн зөвшөөрөхөө больж, зогсоосон бол уг хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагын алдагдлаас тухайн тайлант үед болон нийт хуримтлагдсан байдлаараа хүлээн зөвшөөрөөгүй байгаа, түүнд хамаарах хувь хэсэг.**

**Хамтын хэлэлцээр болон хараат байгууллага дахь уг байгууллагын хувь оролцоотой холбоотой эрсдэл**

39. **Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (a) **МЗУ17-МЗУ19-р параграфт тусгайлан заасны дагуу, тухайн байгууллагын хамтарсан үйлдвэрүүдтэй холбоотой баталгааг бусад баталгааны дүнгүүдээс тусад нь; ба**
  - (б) **Гарзын магадлал маш бага байхаас бусад тохиолдолд, УСНББОУС 19 Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй**

**Хөрөнгө-д заасны дагуу, тухайн хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь түүний хувь оролцоотой холбоогоор хүлээх болзошгүй өр төлбөрийг (үүн дотроо, хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагыг хамтран хянадаг эсвэл мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг хөрөнгө оруулагчидтай хамт хүлээх болзошгүй өр төлбөрөөс өөрт хамаарах хэсгийг) бусад болзошгүй өр төлбөрийн дүнгээс тусад нь.**

### **Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь хувь оролцоо**

40. **Байгууллага нь дараах боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна:**
- (a) **Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь өөрийн хувь оролцооны шинж төрөл ба хэмжээг ойлгох (43-45-р параграф); ба**
  - (б) **Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь өөрийн хувь оролцоотой холбоотой эрсдлийн шинж төрөл ба эрсдлийн өөрчлөлтийг үнэлэх (46-48-р параграф).**
41. Хэдийгээр байгууллага нь тайлант үеийн эцэст уг тусгай бүтэц бүхий байгууллагуудтай заавал биелүүлэх хэлцлийн замаар аливаа оролцоотой байхаа больсон боловч өмнөх тайлант үеүдэд тэдгээр нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагуудтай холбоотой (жишээлбэл; тусгай бүтэц бүхий байгууллагыг санхүүжүүлж) байсны улмаас тухайн байгууллагад учрах эрсдлийн талаархи мэдээлэл нь 40(б) параграфтаар шаардсан мэдээлэлд хамаарна.
42. Хөрөнгө оруулалтын байгууллага нь хянадаг боловч нэгтгэдэггүй бөгөөд 27-33-р параграфтаар шаардсан тодруулгыг түүнд зориулан толилуулдаг, тийм тусгай бүтэц бүхий байгууллагын хувьд 40-р параграфтаар шаардсан тодруулгыг бэлтгэх шаардлагагүй юм.

### **Хувь оролцооны шинж төрөл**

43. **Байгууллага нь нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь өөрийн хувь оролцооны талаархи тоон болон чанарын мэдээллийг тодруулна, үүн дотроо уг тусгай бүтэц бүхий байгууллагын шинж төрөл, зорилго, хэмжээ, үйл ажиллагаа болон тэрхүү тусгай бүтэц бүхий байгууллагыг хэрхэн санхүүжүүлдэг талаар тодруулах боловч үүгээр хязгаарлагдахгүй.**
44. **Байгууллага нь нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагыг санхүүжүүлдэг бөгөөд (жишээлбэл; тухайн тайлант үеийн эцэст тэрхүү тусгай бүтэц бүхий байгууллагад хувь оролцоогүй болсны улмаас) түүний талаар 46-р параграфтаар шаардсан мэдээллийг бэлтгэдэггүй бол тухайн байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**

- (a) Тусгай бүтэц бүхий аль байгууллагад санхүүжилт олгохоо хэрхэн тодорхойлсон гэдгээ;
  - (б) Тухайн тайлант үеийн туршид тэдгээр тусгай бүтэц бүхий байгууллагуудаас олсон орлого, үүн дотроо, уг толилуулсан орлогын төрлийн талаархи тайлбар тодорхойлолтыг; ба
  - (в) Тухайн тайлант үеийн туршид тэдгээр тусгай бүтэц бүхий байгууллагуудад шилжүүлсэн бүх хөрөнгийн (тэрхүү шилжүүлэлтийн өдрөөрх) дансны үнэ.
45. Өөр хэлбэр загвар илүү тохиромжтой байхаас бусад тохиолдолд, байгууллага нь 44(б) ба (в) параграфт дурдсан мэдээллийг хүснэгтэн хэлбэрээр толилуулах бөгөөд өөрийн санхүүжүүлэлтийн үйл ажиллагааг зохих ангиллын дагуу ангилж харуулна (МЗУ2-МЗУ6-р параграфыг үзнэ үү).

#### Эрсдлийн шинж төрөл

46. Өөр хэлбэр загвар илүү тохиромжтой байхаас бусад тохиолдолд, байгууллага нь дараах зүйлсийн нэгтгэл товчоог хүснэгтэн хэлбэрээр тодруулна:
- (a) Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь хувь оролцоотой холбоотойгоор өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ;
  - (б) Тэдгээр хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн, тухайн санхүүгийн байдлын тайлангийн мөрийн зүйлс;
  - (в) Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь өөрийн хувь оролцооноос тухайн байгууллага алдагдал хүлээх хамгийн их эрсдлийг хамгийн сайн төлөөлөн илэрхийлэх дүн, үүн дотроо гарзын тэрхүү хамгийн их эрсдлийг хэрхэн тодорхойлсон эсэх. Хэрэв байгууллага нь нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь өөрийн хувь оролцооноос алдагдал хүлээх хамгийн их эрсдлийг тоон дүнгээр илэрхийлж чадахгүй бол тухайн байгууллага нь энэ тухай, түүнчлэн түүний шалтгааны талаар тодруулга хийнэ; ба
  - (г) Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь түүний хувь оролцоотой холбоотой тухайн байгууллагын хөрөнгө, төлбөрийн дансны үнэ ба тэдгээр тусгай бүтэц бүхий байгууллагуудаас үүсэх алдагдлыг уг байгууллага хүлээх хамгийн их эрсдлийн хоорондох харьцуулалт.
47. Байгууллага нь хэдийгээр заавал биелүүлэх хэлцлийн дагуу ийм үүрэг хүлээгээгүй боловч өмнө нь, эсвэл одоо хувь оролцоотой байгаа, тэрхүү нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагад тухайн тайлант үед санхүүгийн буюу бусад дэмжлэг үзүүлсэн (жишээлбэл; уг тусгай бүтэц бүхий байгууллагын хөрөнгийг эсвэл түүний гаргасан

хэрэглүүрийг худалдан авах) бол уг байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Үзүүлсэн дэмжлэгийн төрөл ба дүн, үүн дотроо, тухайн байгууллага нь санхүүгийн дэмжлэгийг олж авахад уг тусгай бүтэц бүхий байгууллагад туслалцаа үзүүлсэн нөхцөл байдал; ба
- (б) Дэмжлэг үзүүлсэн шалтгаан.

48. Байгууллага нь нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагад санхүүгийн буюу бусад дэмжлэг үзүүлэх одоогийн аливаа сэдэл төлөвлөгөө, үүн дотроо санхүүгийн дэмжлэгийг олж авахад уг тусгай бүтэц бүхий байгууллагад туслах сэдэл төлөвлөгөөгөө тодруулна. Ийм сэдэл төлөвлөгөө нь заавал биелүүлэх хэлцлийн дагуу хүлээсэн үүргийн үр дүнд дэмжлэг үзүүлэх сэдэл төлөвлөгөө ба заавал биелүүлэх хэлцлийн дагуу тухайн байгууллага үүрэг хүлээгээгүй үед дэмжлэг үзүүлэх сэдэл төлөвлөгөөг агуулсан байдаг.

### **Тоогоор илэрхийлэх боломжгүй өмчлөлийн хувь оролцоо**

49. Байгууллага нь бусад байгууллагууд дахь тоогоор илэрхийлэх боломжгүй аливаа өмчлөлийн хувь оролцооны шинж төрөл ба хэмжээг ойлгох боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна.
50. Уг мэдээллийг энэ Стандартын дагуу аль хэдийн бэлтгэн толилуулаагүй тохиолдолд тухайн байгууллага нь тэрхүү тайлагнагч байгууллагын хувьд материаллаг байх, тоогоор илэрхийлэх боломжгүй өмчлөлийн хувь оролцоо нэг бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:
- (а) Өмчлөлийн хувь оролцоо бүхий байгууллагын нэр; ба
  - (б) Тухайн байгууллага дахь түүний өмчлөлийн хувь оролцооны шинж төрөл.

### **Худалдан борлуулах зорилгоор олж эзэмшсэн хяналтын хувь оролцоо**

51. Хөрөнгө оруулалтын байгууллагаас бусад байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь өөрийн хувь оролцоог тэрхүү хяналт үүссэн үед худалдан борлуулах сэдэл төлөвлөгөөтэй байсан бөгөөд тухайн тайлангийн өдөр энэхүү хувь оролцоогоо худалдан борлуулах идэвхитэй сэдэл төлөвлөгөөтэй байгаа бол түүний талаархи мэдээллийг тодруулна.
52. Улсын секторын байгууллага нь бусад байгууллагын хяналтыг олж авсан боловч уг хяналтанд буй бүх буюу зарим хувь оролцоогоо ойрын ирээдүйд худалдан борлуулах идэвхитэй сэдэл төлөвлөгөөтэй байх тийм олон тохиолдол байдаг.

53. Улс орны эдийн засгийн аж байдлын төлөө төрийн хүлээх өргөн хүрээтэй хариуцлагын улмаас Засгийн газар нь санхүүгийн байгууллага гэх мэт байгууллагын алдаа, дутагдлаас урьдчилан сэргийлэхийн тулд хөндлөнгөөс оролцож болох юм. Хэдийгээр засгийн газар нь тухайн байгууллагыг хянах сэдэл төлөвлөгөөгүй боловч ийм хөндлөнгийн оролцоо нь бусад байгууллагын хяналтыг засгийн газар авахад хүргэж болох юм. Харин засгийн газрын сэдэл төлөвлөгөө нь уг хяналтанд буй байгууллага дахь өөрийн хувь оролцоог худалдан борлуулах эсвэл бусад байдлаар данснаас хасах явдал байж болно. Ийм данснаас хасалтанд туслалцаа үзүүлэхийн тулд уг бусад байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай бол ийм бүтцийн өөрчлөлтийг нэг буюу хэд хэдэн жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд засгийн газар нь энэхүү үйл явцын эцэст үлдсэн зарим хөрөнгө, өр төлбөрийг хадгалан үлдэж болох юм. Хяналт оршин буй тайлант үеүдэд эдгээр хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэх нь тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болох юм. Алдаа дутагдлаас урьдчилан сэргийлэх ийм хөндлөнгийн оролцооны үр дүнд хяналтыг олж авах нь засгийн газрын хувьд гарч тохиолдох өндөр магадлалтай боловч улсын секторын бие даасан байгууллагуудын хувьд мөн ийм тохиолдол үүсэж болно.
54. Улсын секторын байгууллага нь бусад байгууллага дахь бүх буюу зарим хяналтын хувь оролцоог засгийн газрын бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс худалдан борлуулах сэдэл төлөвлөгөөтэйгээр мөн олж эзэмшиж болох юм. Жишээлбэл; засгийн газар нь дахин хуваарилалт хийх зорилгоор бусад байгууллагуудын зарим хувь оролцоог олж эзэмших удирдамж чиглэлийг тухайн байгууллагад өгч болох юм.
55. **Байгууллага нь 51-р параграфт дурдсан, хяналтанд буй байгууллага нэг бүрийн хувьд дараах мэдээллийг тодруулга хэсэгт толилуулна:**
- (а) **Хяналтанд буй байгууллагын нэр ба түүний үндсэн үйл ажиллагааны талаархи тайлбар тодорхойлолт;**
  - (б) **Хяналтын хувь оролцоог олж эзэмшсэн учир шалтгаан ба хяналт оршин буй эсэхийг тодорхойлохдоо харгалзан үзэх хүчин зүйлс;**
  - (в) **Уг хяналтанд буй байгууллагыг нэгтгэж буй тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө, үүн дотроо хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал, цэвэр хөрөнгө/ өмчид үзүүлэх нөлөө; ба**
  - (г) **Данснаас хасалтын арга хандлагын одоогийн төлөв байдал, үүн дотроо данснаас хасалтын хүлээгдэж буй арга ба хугацаа.**
56. **55-р параграфтаар шаардсан тодруулгыг тухайн байгууллага нь хяналтын хувь оролцоогоо данснаас хасах эсвэл уг хувь оролцоогоо данснаас хасах сэдэл төлөвлөгөөг болих хүртэлх тайлант үе бүрийн эцэст бэлтгэж толилуулна. Байгууллага нь хяналтын хувь оролцоогоо данснаас хассан эсвэл уг хяналтын хувь оролцоогоо данснаас хасах сэдэл төлөвлөгөөгөө больсон тайлант үед дараах зүйлсийг тодруулна:**

- (a) Данснаас хасалт эсвэл сэдэл төлөвлөгөөний өөрчлөлтийн тухай; ба
  - (б) Нэгтгэсэн санхүүгийн тайланд уг данснаас хасалт буюу сэдэл төлөвлөгөөний өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөө.
57. Энэ Стандарт болон бусад УСНББОУС-аар шаардсан бусад тодруулга нь 55 эсвэл 56-р параграфт хамаарах мэдээллээр хангадаг тохиолдолд тэдгээр бусад тодруулгад хийсэн харилцан лавлагааг тусган харуулна.

### Шилжилтийн нөхцөл

58. Байгууллага нь энэ Стандартаар шаардсан мэдээллийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант жилээс өмнөх хугацаанд бэлтгэж толилуулахыг дэмжинэ. Энэ Стандартаар шаардсан зарим тодруулгыг бэлтгэж толилуулах нь тухайн байгууллага энэ Стандартын бүх шаардлагуудыг даган мөрдөх, эсвэл УСНББОУС 34, УСНББОУС 35, УСНББОУС 36, УСНББОУС 37-г тэдгээрийн дурдсан хугацаанаас өмнө заавал мөрдөх үүрэг хүлээлгэхгүй.
59. Энэ Стандартыг мөрдсөн анхны тайлант жилийн яг өмнөх тайлант жилээс өмнө эхлэх аливаа толилуулсан тайлант үеийн хувьд энэ Стандартын тодруулгын шаардлагуудыг мөрдөх албагүй юм.
60. Энэ Стандартыг мөрдсөн анхны тайлант жилээс өмнө эхлэх аливаа толилуулсан тайлант үеийн хувьд энэ Стандартын 40-56-р параграфын тодруулгын шаардлагууд болон МЗУ20-МЗУ25-р параграфын харгалзах заавар удирдамжийг мөрдөх албагүй юм.

### Хүчин төгөлдөр болох хугацаа

61. Байгууллага нь энэхүү Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
- 61А. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 5, 6-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 61Б. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 4-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв

**байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.**

62. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.



## Хавсралт А

### Мөрдөх заавар удирдамж

*Энэ Хавсралт нь УСНББОУС 38-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

МЗУ1. Энэ Хавсралт дахь жишээнүүд нь таамагласан нөхцөл байдлуудыг илэрхийлнэ. Хэдийгээр эдгээр жишээний зарим төлөв байдал нь бодит нөхцөл байдалд илрэн гарч болох боловч энэ Стандартыг мөрдөх үедээ тухайн тодорхой хэв загварын бүх баримт материал болон нөхцөл байдлыг үнэлэх шаардлагатай байдаг.

### Нэгтгэн нийлүүлэлт (11-р параграф)

МЗУ2. Өөрийн нөхцөл байдлыг харгалзан байгууллага нь хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахын тулд хэр их дэлгэрэнгүй мэдээллээр хангах, хэрэгцээ шаардлагын янз бүрийн төлөв байдалд хэр их ач холбогдол өгөх, тухайн мэдээллийг хэрхэн нэгтгэн нийлүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тус дэм болохгүй хэт дэлгэрэнгүй мэдээллээр санхүүгийн тайланг дүүргэх эсвэл хэт нэгтгэн нийлүүлсний улмаас мэдээллийг бүрхэгдүүлэхийн хоорондох тэнцвэрийг олох шаардлагатай байдаг.

МЗУ3. Хэрэв нэгтгэн нийлүүлэлт нь МЗУ4-р параграфт заасан тодруулгын зорилго ба шаардлагатай нийцэх бөгөөд тухайн хангах мэдээллийг бүрхэгдүүлэхгүй бол байгууллага нь ижил төсөөтэй байгууллагууд дахь хувь оролцооны хувьд энэ Стандартаар шаардсан тодруулгуудыг нэгтгэж болох юм. Байгууллага нь ижил төсөөтэй байгууллагууд дахь өөрийн хувь оролцоог хэрхэн нэгтгэсэн гэдгээ тодруулна.

МЗУ4. Байгууллага нь дараах байгууллагууд дахь хувь оролцооны хувьд мэдээллийг тусдаа толилуулна:

- (а) Хяналтанд буй байгууллагууд;
- (б) Хамтарсан үйлдвэр;
- (в) Хамтын үйл ажиллагаа;
- (г) Хараат байгууллага; ба
- (д) Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд.

МЗУ5. Мэдээллийг нэгтгэн нийлүүлэх эсэхийг тодорхойлохдоо, тухайн тайлагнагч байгууллага нь түүний хувьд эдгээр байгууллага тус бүрийн нэгтгэн нийлүүлэлт ба материаллаг байдлыг харгалзан үзэж, тэдгээр байгууллага бүрийн янз бүрийн эрсдэл буюу өгөөжийн шинж чанарын талаархи чанарын болон тоон шинжтэй мэдээллийг харгалзана. Тайлагнагч байгууллага нь тэдгээр бусад байгууллагууд дахь өөрийн хувь оролцооны шинж төрөл ба хэмжээг тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ойлгомжтой, тодорхой тайлбарлах байдлаар тодруулгыг толилуулна.

- МЗУ6. МЗУ4-р параграфт дурдсан байгууллагуудын ангиллын хувьд тохиромжтой байж болох нэгтгэн нийлүүлэлтийн түвшний жишээг доор харуулав:
- (а) Үйл ажиллагааны шинж төрөл (жишээлбэл; судалгаа ба хөгжүүлэлтийн байгууллага, эргэлтийн зээлийн картын үнэт цаасжуулалтын байгууллага).
  - (б) Салбарын ангилал.
  - (в) Газарзүйн ангилал (жишээлбэл; улс орон эсвэл бүс нутаг).

### **Бусад байгууллагууд дахь хувь оролцоо**

- МЗУ7. Бусад байгууллагууд дахь хувь оролцоо нь тэрхүү бусад байгууллагын үр дүнгээс бий болох өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд тухайн тайлагнагч байгууллагад эрсдэл учруулдаг заавал биелүүлэх хэлцлийн буюу бусад арга замаар илэрхийлэгдэх оролцоо юм. Бусад байгууллагын зорилго ба бүтцийг харгалзан үзэх нь тэрхүү бусад байгууллагад хувь оролцоотой, иймээс энэ Стандартад заасан тодруулгыг бэлтгэх шаардлагатай эсэхийг үнэлэхэд уг тайлагнагч байгууллагад туслалцаа үзүүлж болох юм. Уг бусад байгууллагыг үүсгэн байгуулснаар үүсэх эрсдэл, түүнчлэн тухайн тайлагнагч байгууллагад болон өөр бусад талуудад шилжүүлэх эрсдлийг харгалзан үзэх нь энэхүү үнэлгээнд хамаарна.
- МЗУ8. Тайлагнагч байгууллага нь бусад байгууллагын хэрэглүүрийг (уг бусад байгууллагын гаргасан өмчийн буюу өрийн хэрэглүүр гэх мэт) эзэмшнээр эсвэл хувьсан өөрчлөлтөнд хамаарах өөр бусад оролцоотой байснаар тэрхүү бусад байгууллагын үр дүнгээс бий болох өгөөжийн хувьсан өөрчлөлтийн эрсдэлд ихэвчлэн өртдөг. Жишээлбэл; тусгай бүтэц бүхий байгууллага нь зээлийн багцыг эзэмшдэг гэж үзье. Тэрхүү тусгай бүтэц бүхий байгууллага нь тухайн зээлийн үндсэн дүнгийн болон хүүний төлбөрийн үл биелүүлэлтээс өөрийгөө хамгаалахын тулд өөр байгууллага (тайлагнагч байгууллага)-аас зээлийн үл биелүүлэлтийн свопыг олж авдаг. Уг зээлийн үл биелүүлэлтийн своп нь тусгай бүтэц бүхий байгууллагын өгөөжийн хувьсан өөрчлөлтөнд хамаарч, түүнийг өөртөө шингээх учраас тухайн тайлагнагч байгууллага нь тэрхүү тусгай бүтэц бүхий байгууллагын үр дүнгээс бий болох өгөөжийн хувьсан өөрчлөлтийн эрсдэлд өртөх, тийм оролцоотой байна.
- МЗУ9. Зарим хэрэглүүр нь эрсдлийг тухайн тайлагнагч байгууллагаас өөр бусад байгууллагад шилжүүлэх зорилго чиглэлтэй байдаг. Ийм хэрэглүүр нь өгөөжийн хувьсан өөрчлөлтийг тэрхүү бусад байгууллагад хүлээлгэдэг боловч уг бусад байгууллагын үр дүнгээс бий болсон өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд тухайн тайлагнагч байгууллагад ихэвчлэн эрсдэл учруулдаггүй. Жишээлбэл; “Зэт” байгууллагын (“Зэт” байгууллага нь уг хэлэлцээрт оролцогч аль нэг талтай холбоогүй) зээлийн эрсдлийг хариуцахыг хүссэн, хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтын боломж олгохын тулд тусгай бүтэц бүхий байгууллагыг үүсгэн байгуулсан гэж үзье. Тухайн тусгай бүтэц бүхий байгууллага нь тэрхүү “Зэт”

байгууллагын зээлийн эрсдэлтэй холбоотой өрийн бичиг (зээлтэй холбоотой өрийн бичиг)-ийг тэдгээр хөрөнгө оруулагчдад гаргаснаар санхүүжилт олж авсан бөгөөд эрсдэлгүй санхүүгийн хөрөнгийн багцад хөрөнгө оруулалт хийхийн тулд уг орлогыг ашигладаг. Уг тусгай бүтэц бүхий байгууллага нь свопын оролцогч талтай зээлийн үл биелүүлэлтийн свопын (ЗҮБС) гэрээ байгуулах замаар тэрхүү “Зэт” байгууллагын зээлийн эрсдлийг хариуцдаг. Энэхүү ЗҮБС нь тухайн свопын оролцогч талын төлөх шимтгэлийн хариуд “Зэт” байгууллагын зээлийн эрсдлийг уг тусгай бүтэц бүхий байгууллагад шилжүүлнэ. Энэхүү тусгай бүтэц бүхий байгууллагын хөрөнгө оруулагч нар нь түүний хөрөнгийн багцаас үүсэх уг тусгай бүтэц бүхий байгууллагын өгөөж болон ЗҮБС-ын шимтгэлийн аль алинаас бүрдэх илүү өндөр өгөөжийг хүртэх юм. ЗҮБС нь тусгай бүтэц бүхий байгууллагын өгөөжийн хувьсан өөрчлөлтийн эрсдэлд хамаарч, түүнийг шингээхгүй, харин уг тусгай бүтэц бүхий байгууллагад шилжүүлдэг учраас тухайн свопын оролцогч тал нь тусгай бүтэц бүхий байгууллагын үр дүнгээс үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн эрсдэлд өртөх тэрхүү тусгай бүтэц бүхий байгууллагад оролцоогүй байна.

### **Хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллагын хураангуй санхүүгийн мэдээлэл (19 ба 36-р параграф)**

МЗУ10. Тухайн тайлагнагч байгууллагын хувьд материаллаг байх, хяналтын бус хувь оролцоотой хяналтанд буй байгууллага тус бүрийн хувьд уг байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Хяналтын бус хувь оролцоонд төлсөн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт; ба
- (б) Эдийн засгийн нэгдмэл байгууллагын үйл ажиллагаа болон мөнгөн гүйлгээнд хяналтын бус хувь оролцоотой байх хувь оролцоог ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгох тухайн хяналтанд буй байгууллагын хөрөнгө, өр төлбөр, ашиг буюу алдагдал, мөнгөн гүйлгээний талаархи хураангуй санхүүгийн мэдээлэл. Энэхүү мэдээлэлд, тухайлбал эргэлтийн хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр, орлого, ашиг буюу алдагдал хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй.

МЗУ11. МЗУ10(б) параграфтаар шаардсан, хураангуй санхүүгийн мэдээлэл нь байгууллага хоорондын устгалтын өмнөх дүн байна.

МЗУ12. Тухайн тайлагнагч байгууллагын хувьд материаллаг байх, хамтарсан үйлдвэр болон хараат байгууллага тус бүрийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагаас хүлээн авсан ногдол ашиг болон адилтгах хуваарилалт;
- (б) Хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагын талаархи хураангуй санхүүгийн мэдээлэл (МЗУ14 ба МЗУ15-р параграфыг үзнэ үү), үүнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (i) Эргэлтийн хөрөнгө;
- (ii) Эргэлтийн бус хөрөнгө;
- (iii) Богино хугацаат өр төлбөр;
- (iv) Урт хугацаат өр төлбөр;
- (v) Орлого;
- (vi) Татварын зардал;
- (vii) Зогсоосон үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийн данснаас хасалт буюу өр төлбөрийн барагдуулалтаар хүлээн зөвшөөрсөн татварын өмнөх олз, гарз; ба
- (viii) Ашиг, алдагдал.

МЗУ13. МЗУ12-р параграфтаар шаардсан, хураангуй санхүүгийн мэдээллээс гадна байгууллага нь тухайн тайлагнагч байгууллагын хувьд материаллаг байх хамтарсан үйлдвэр тус бүрийн хувьд дараах зүйлсийн дүнг тодруулна:

- (a) МЗУ12(б)(i) параграфт хамаарах, мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө;
- (б) МЗУ12(б)(iii) параграфт хамаарах, богино хугацаат санхүүгийн өр төлбөр (үүнд: татвар ба шилжүүлгийн өглөг, арилжааны ажил гүйлгээний өглөг, нөөц хамаарахгүй);
- (в) МЗУ12(б)(iv) параграфт хамаарах, урт хугацаат санхүүгийн өр төлбөр (үүнд: татвар ба шилжүүлгийн өглөг, арилжааны ажил гүйлгээний өглөг, нөөц хамаарахгүй);
- (г) Элэгдэл ба хорогдуулга;
- (д) Хүүний орлого;
- (е) Хүүний зардал; ба
- (ж) Орлогын албан татварын зардал.

МЗУ14. МЗУ12 ба МЗУ13-р параграфын дагуу толиуулсан, хураангуй санхүүгийн мэдээлэл нь тухайн хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагын УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланд тусгасан дүнгүүд (харин тэдгээр дүнгүүдээс уг байгууллагад хамаарах хэсэг биш) байна. Хэрэв байгууллага нь хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь өөрийн хувь оролцоогоо өмчийн арга ашиглан тайлагнадаг бол:

- (a) Худалдан авалтын үед хийсэн бодит үнэ цэнийн залруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлогын зөрүүтэй байдлын залруулга гэх мэт тухайн байгууллага нь өмчийн арга хэрэглэх үедээ хийсэн залруулгуудыг тусгахын тулд уг хамтарсан үйлдвэр болон хараат байгууллагын УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланд толилуулах дүнгүүдийг залруулна.

- (б) Тухайн байгууллага нь уг толилуулсан хураангуй санхүүгийн мэдээллийг тэрхүү хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь өөрийн хувь оролцооны дансны үнэтэй тааруулах тохируулгын тайланг бэлтгэнэ.

МЗУ15. Дараах тохиолдолд байгууллага нь МЗУ12 ба МЗУ13-р параграфтаар шаардсан, хураангуй санхүүгийн мэдээллийг уг хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагын санхүүгийн тайланд үндэслэн толилуулж болно:

- (а) Тухайн байгууллага нь уг хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь өөрийн хувь оролцоог УСНББОУС 36-гийн дагуу бодит үнэ цэнээр хэмждэг; ба
- (б) Уг хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага нь УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэдэггүй бөгөөд ийм санхүүгийн тайлан бэлтгэх практик боломжгүй эсвэл хэт их зардал гаргахад хүргэдэг.

Энэ тохиолдолд, тухайн байгууллага нь уг хураангуй санхүүгийн мэдээллийг бэлтгэсэн сууриа тодруулна.

МЗУ16. Байгууллага нь өмчийн арга ашиглан тайлагнадаг, бие даасан байдлаараа материаллаг бус бүх хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь өөрийн хувь оролцооны дансны үнийг нэгтгэн нийлүүлсэн байдлаар тодруулна. Мөн байгууллага нь тэдгээр хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллагын дараах зүйлсийн хувьд өөрт ногдох хэсгийг тусад нь тодруулна:

- (а) Орлого.
- (б) Татварын зардал.
- (в) Зогсоосон үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийн данснаас хасалт буюу өр төлбөрийн барагдуулалтаар хүлээн зөвшөөрсөн татварын өмнөх олз, гарз.
- (г) Ашиг, алдагдал.
- (д) Байгууллага нь хамтарсан үйлдвэрүүд болон хараат байгууллагуудын хувьд тодруулгыг тус тусад нь бэлтгэнэ.

### **Хамтарсан үйлдвэрт олгосон баталгаа (39(а) параграф)**

МЗУ17. Байгууллага нь хамтарсан үйлдвэр дэх өөрийн хувь оролцоотой холбоотойгоор гаргасан боловч тухайн тайлант үеийн эцэст хүлэн зөвшөөрөөгүй байгаа нийт баталгааг (үүн дотроо, хамтарсан үйлдвэрт хамтын хяналт тавьдаг бусад хөрөнгө оруулагч нартай хамтран гаргасан баталгаанаас өөрт хамаарах хэсгийг) тодруулна. Ийм баталгаа нь мөнгө буюу бусад нөөцийн ирээдүйн зарлага гарахад хүргэж болох баталгаа юм.

МЗУ18. Мөнгө буюу бусад нөөцийн ирээдүйн зарлага гарахад хүргэж болох, хүлээн зөвшөөрөөгүй байгаа баталгаанд<sup>1</sup> дараах зүйлс хамаарна:

- (a) Тухайлбал; дараах зүйлсийн үр дүнд санхүүжилт буюу нөөцөөр хувь нийлүүлэх талаархи хүлээн зөвшөөрөөгүй байгаа баталгаа:
  - (i) Хамтарсан үйлдвэрийн үүсгэн байгуулах гэрээ буюу худалдан авалтын гэрээ (энэ нь тухайлбал, тогтоосон хугацаанд мөнгө сангаар хувь нийлүүлэхийг уг байгууллагаас шаарддаг).
  - (ii) Хамтарсан үйлдвэрийн хэрэгжүүлсэн капиталыг нэмэгдүүлэх төслүүд.
  - (iii) Худалдан авалтын нөхцөлт бус үүрэг, энэ нь хамтарсан үйлдвэрээс эсвэл түүний нэрийн өмнөөс худалдан авахаар тухайн байгууллагын баталгаа гаргасан тоног төхөөрөмж, бараа, үйлчилгээний нийлүүлэлтээс бүрдэнэ.
  - (iv) Хамтарсан үйлдвэрт зээл буюу бусад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хүлээн зөвшөөрөөгүй байгаа баталгаа.
  - (v) Хамтарсан үйлдвэрт хөрөнгө, үйлчилгээ гэх мэт нөөцөөр хувь нийлүүлэх, хүлээн зөвшөөрөөгүй байгаа баталгаа.
  - (vi) Хамтарсан үйлдвэртэй холбоотой бусад үл цуцлагдах, хүлээн зөвшөөрөөгүй байгаа баталгаа.
- (б) Хэрэв тодорхой үйл явдал ирээдүйд тохиолдвол эсвэл тохиолдохгүй бол хамтарсан үйлдвэр дэх өөр талын өмчлөлийн хувь оролцоог (эсвэл уг хувь оролцооны тодорхой хэсгийг) худалдаж авах хүлээн зөвшөөрөгдөөгүй төлбөрийн хариуцлагууд хамаарна.

МЗУ19. МЗУ17 ба МЗУ18-р параграфын шаардлагууд болон жишээ нь УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-ын 27-р параграфтаар шаардсан, тодруулгын зарим төрлийг үлгэрчлэн харуулсан болно.

## **Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь хувь оролцоо (40-48-р параграф)**

### **Тусгай бүтэц бүхий байгууллагууд**

МЗУ20. Тусгай бүтэц бүхий байгууллага гэдэг нь тухайн байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд байгууллагыг хянах уламжлалт тогтсон арга зам голлох хүчин зүйл биш байхаар зохион байгуулсан байгууллага юм.

---

<sup>1</sup> Энэ Стандартад дурдсан, “хүлээн зөвшөөрөх”, “үл хүлээн зөвшөөрөх” гэсэн хэллэг нь тухайн зүйлийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, тусгах эсвэл тусгахгүй байх гэсэн утгыг илэрхийлнэ. Жишээлбэл; “хүлээн зөвшөөрөөгүй байгаа баталгаа” гэдэг нь гаргасан баталгаагаа зөвшөөрөх эсвэл үгүйсгэх гэсэн утгатай биш, харин санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, тусгаагүй, өөрөөр хэлбэл, балансын гадуур байгаа гэсэн утгыг илэрхийлж байна. Ред.Ч.Д.

Байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд захиргааны зохицуулалт буюу хууль тогтоомж нь ихэвчлэн голлох хүчин зүйл болдог газар хэлтэс, яам гэх мэт байгууллагуудын хувьд тусгай бүтэц бүхий байгууллага нь тэрхүү байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд уг захиргааны зохицуулалт буюу хууль тогтоомж голлох хүчин зүйл биш байхаар зохион байгуулсан байгууллага байдаг. Байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд саналын буюу адилтгах эрх нь ихэвчлэн голлох хүчин зүйл болдог байгууллагуудын хувьд (ашиг олох зорилго бүхий зарим байгууллагуудын хувьд ийм тохиолдол үүсэж болно) тусгай бүтэц бүхий байгууллага нь тэрхүү байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд уг саналын буюу адилтгах эрх нь голлох хүчин зүйл биш байхаар зохион байгуулсан байгууллага юм. Улсын секторын байгууллагуудын хооронд заавал биелүүлэх хэлцлийг байнга байгуулаад байдаггүй боловч байгууллагыг хэн хянаж буй эсэхийг тодорхойлоход заавал биелүүлэх хэлцэл ихэвчлэн голлох хүчин зүйл болдоггүй. Иймээс байгууллагын холбогдох үйл ажиллагааг тодорхойлохын тулд заавал биелүүлэх хэлцлийг ашиглах нь тусгай бүтэц бүхий байгууллага оршин байгааг илэрхийлж болох юм. Тухайн нөхцөл байдлаас хамааран тусгай бүтэц бүхий байгууллага нь дараах байгууллага байж болно: (i) ихэнх үйл ажиллагаа нь урьдчилан тодорхойлогдсон бөгөөд цар хүрээний хувьд хязгаарлагдсан боловч заавал биелүүлэх хэлцлээр дамжуулан удирдан чиглүүлэгдэх тийм холбогдох үйл ажиллагаа бүхий байгууллага, эсвэл (ii) аливаа саналын эрх нь зөвхөн захиргааны ажил үүрэгтэй холбоотой бөгөөд холбогдох үйл ажиллагааг нь заавал биелүүлэх хэлцлээр удирдан чиглүүлдэг байгууллага.

МЗУ21. Тусгай бүтэц бүхий байгууллага нь ихэвчлэн дараах бүх буюу зарим шинж, онцлогтой байдаг:

- (а) Хязгаарлагдмал үйл ажиллагаатай.
- (б) Нарийн, маш сайн тодорхойлсон зорилготой. Жишээлбэл; судалгаа ба хөгжүүлэлтийн үйл ажиллагаа явуулах, байгууллагад капиталын буюу санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх, уг тусгай бүтэц бүхий байгууллагын хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг хөрөнгө оруулагчдад шилжүүлэх замаар тэдгээр хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын боломж олгох гэх мэт.
- (в) Хангалттай бус цэвэр хөрөнгө/өмчтэй байх, ингэснээр уг тусгай бүтэц бүхий байгууллага нь тэргүүн бус ээлжийн эрхтэй санхүүгийн дэмжлэггүй боловч өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэн явуулах боломжтой байх.
- (г) Зээлийн буюу бусад эрсдлийн төвлөрөл (багц) үүсгэдэг хөрөнгө оруулагч нарт гэрээгээр холбогдсон олон хэрэглүүр хэлбэрээр санхүүжилт хийх.

МЗУ22. Тусгай бүтэц бүхий байгууллага гэж үзэж болох байгууллагын жишээнд дараах байгууллага хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

## БУСАД БАЙГУУЛЛАГУУД ДАХЬ ХУВЬ ОРОЛЦООНЫ ТОДРУУЛГА

- (а) Хамтарсан үйлдвэр биш боловч заавал биелүүлэх хэлцлээр үүсгэн байгуулж, удирдан чиглүүлдэг нөхөрлөл хэлбэртэй байх, төр ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хоорондын түншлэл.
  - (б) Үнэт цаасжуулалтын хэрэгсэл.
  - (в) Хөрөнгөөр баталгаажсан санхүүжилт.
  - (г) Зарим хөрөнгө оруулалтын сан.
- МЗУ23. Бусад байгууллагад засгийн газраас санхүүжилт олгож буй байдал нь уг байгууллагыг тусгай бүтэц бүхий байгууллага гэж үзэхэд хүргэхгүй юм. Саналын эрхийн хяналтанд байдаг байгууллага нь тухайлбал, тусгай бүтэцтэй болгосны дараа гуравдагч талаас санхүүжилт хүлээн авдаг учраас түүнийг тусгай бүтэц бүхий байгууллага гэж шууд үзэхгүй.

### **Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь хувь оролцооны эрсдлийн шинж төрөл (46-48-р параграф)**

- МЗУ24. 46-48-р параграфтаар шаардсан мэдээллээс гадна, байгууллага нь 40(б) параграфт дурдсан, тодруулгын зорилгыг ханган биелүүлэхэд шаардлагатай нэмэлт мэдээллийг тодруулна.
- МЗУ25. Байгууллага нь нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагад хувь оролцоотой байх тохиолдолд түүнд учрах эрсдлийн үнэлгээнд ач холбогдолтой байж болох бөгөөд тухайн нөхцөл байдлаас хамаарах нэмэлт мэдээллийн жишээ нь:
- (а) Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг тухайн байгууллагаас шаардаж болох уг хэлэлцээрийн нөхцлүүд (жишээлбэл; тусгай бүтэц бүхий байгууллагын хөрөнгийг худалдан авах эсвэл түүнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй холбоотой, төлбөрийн чадварын хэлэлцээр болон зээлийн зэрэглэл тогтоох арга механизм), үүнд:
    - (i) Тухайн тайлагнагч байгууллагад алдагдал учруулж болох үйл явдал буюу нөхцөл байдлуудын тайлбар тодорхойлолт.
    - (ii) Уг үүргийг хязгаарлах ямар нэг нөхцөл байгаа эсэх.
    - (iii) Санхүүгийн дэмжлэг үзүүлэх өөр бусад талууд байгаа эсэх, хэрэв байгаа бол тэдгээр бусад талуудын үүрэгтэй харьцуулахад уг тайлагнагч байгууллагын үүрэг ямар түвшинд байгаа эсэх.
  - (б) Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь өөрийн хувь оролцоотой холбоотойгоор тухайн тайлант үед уг байгууллагын хүлээсэн алдагдал.
  - (в) Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь өөрийн хувь оролцооноос тухайн тайлант үед уг байгууллагын хүлээн авсан орлогын төрөл.



## БУСАД БАЙГУУЛЛАГУУД ДАХЬ ХУВЬ ОРОЛЦООНЫ ТОДРУУЛГА

- (г) Байгууллага нь нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагын алдагдлыг бусад талуудаас түрүүлж хариуцах шаардлагатай эсэх, уг байгууллагын ингэж хариуцах алдагдлын хамгийн их хэмжээ хязгаар, түүнчлэн (хэрэв хамааралтай бол) тэрхүү нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагад тухайн тайлагнагч байгууллагаас бага хувь оролцоотой бусад талуудын хариуцах, боломжит алдагдлын дүн ба тэдгээрийн харьцуулсан түвшин.
- (д) Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагууд дахь тухайн байгууллагын хувь оролцооны бодит үнэ цэнэ буюу эрсдэлд нөлөөлж болох аливаа төлбөрийн чадварын хэлэлцээр, хөрөнгийн баталгаа буюу гуравдагч талд гарган өгсөн бусад баталгааны талаархи мэдээлэл.
- (е) Уг нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллага нь өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд тухайн тайлант үед тулгарсан аливаа хүндрэл, саад бэрхшээл.
- (ж) Нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагын санхүүжилттэй холбоотойгоор, санхүүжилтийн хэлбэр (жишээлбэл; богино буюу дунд хугацааны өрийн бичиг) ба тэдгээрийн жинэлсэн дундаж хугацаа. Тухайн нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллага нь богино хугацаат эх үүсвэрээр санхүүжүүлсэн урт хугацаат хөрөнгүүдтэй бол тэрхүү нэгтгэдэггүй, тусгай бүтэц бүхий байгууллагын хөрөнгө ба эх үүсвэрийн дуусгавар болох хугацааны шинжилгээг энэхүү мэдээлэлд тусгаж болох юм.

## **Хавсралт Б**

### **Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт**

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 38, Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Зорилго

ДҮ1. УСНББОУС 38-ын дүгнэлтүүдэд хүрэхдээ УСНББОУС3-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. Энэ Стандарт нь НББОУС3-өөс гаргасан, СТОУС 12, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга* (2011 онд гаргасан ба үүн дотроо, 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүд)-д үндэслэсэн тул УСНББОУС 38 нь СТОУС 12-ын гол шаардлагуудаас гажсан зөвхөн тэдгээр талбаруудыг Дүгнэлтийн Үндэслэлд хамруулсан.

### Тойм

ДҮ2. УСНББОУС3 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны тайлагналыг зохицуулах УСНББОУС-уудыг шинэчлэх төслийн ажлыг 2012 онд эхэлсэн. *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцоо* гэж хамтад нь нэрлэх, Саналын Төсөл (СТ) 48-52-ыг УСНББОУС3 нь 2013 оны 10 дугаар сард гаргасан. СТ 52, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга* нь СТОУС 12, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-д үндэслэсэн бөгөөд УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 7, *Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт*, УСНББОУС 8, *Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо* дахь тодруулгын шаардлагуудын хувьд улсын секторын холбогдох засвар өөрчлөлтүүдийг харгалзан үзсэн. 2015 оны 01 дүгээр сард УСНББОУС3 нь шинэ таван УСНББОУС-ыг, үүн дотроо УСНББОУС 38-ыг гаргасан. Эдгээр шинэ УСНББОУС-ууд нь УСНББОУС 6, УСНББОУС 7, УСНББОУС 8-ыг орлох юм.

### Гол шүүн тунгаалт ба таамаглалууд (12-14-р параграфууд)

ДҮ3. Байгууллага нь бусад байгууллага дахь өөрийн хувь оролцооны шинж төрлийг (жишээлбэл; хяналт, хамтын хяналт, мэдэгдэхүйц нөлөө) тодорхойлохын тулд хийсэн гол шүүн тунгаалт ба таамаглалын талаархи мэдээллийг тодруулахыг СТОУС 12-ын 7-р параграфуудаар шаарддаг гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Эдгээр шүүн тунгаалтыг байгууллага хэрхэн хийсэн талаархи мэдээлэл нь хэрэглэгчдэд хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн боловч тухайн тодорхой байгууллагуудтай холбоотойгоор олон шүүн тунгаалт болон таамаглал хийхийг улсын секторын байгууллагаас шаардах, ийм шүүн тунгаалт ба таамаглал, түүнчлэн нэг тайлан үеэс нөгөө тайлант үед уг шүүн тунгаалтанд орсон өөрчлөлтийг тодруулах нь ач холбогдолгүй, хэт дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэхэд хүргэж болно гэж УСНББОУС3 тэмдэглэсэн. Улсын секторын хувьд тухайн тайлагнагч байгууллагын талаархи шийдвэрийг хууль тогтоох байгууллага буюу хяналтын хороо гэх мэт бусад талуудтай хамтран

боловсруулсан үзэл баримтлалыг харгалзан гаргаж болно гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Хяналтанд буй байгууллага, хамтын хяналтанд буй байгууллага буюу мэдэгдэхүйц нөлөөнд орсон байгууллага зэрэг зарим төрлийн байгууллагуудын ангиллын хувьд хийсэн үнэлгээг тухайн санхүүгийн тайлангаас өөр бусад улсын секторын баримт бичигт тусгаж болох юм. Иймээс байгууллага нь хяналт, хэлэлцээрийн хамтын хяналт, мэдэгдэхүйц нөлөө оршин байгаа эсвэл байхгүй эсэхийг тодорхойлохдоо ашигласан арга зүйгээ тухайн санхүүгийн тайланд эсвэл олон нийтэд танилцуулсан бусад баримт бичигт лавлагаа үүсгэх замаар тусган оруулахыг түүнээс шаардахыг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

**Тусгай бүтэц бүхий байгууллагын тодорхойлолт (7, МЗУ20, МЗУ23-р параграфууд)**

- ДҮ4. СТОУС 12 дахь “тусгай бүтэц бүхий байгууллага”-ын тодорхойлолт нь саналын буюу адилтгах эрхэд голлон чиглэдэг бөгөөд хувийн хэвшилтэй харьцуулахад улсын секторт харьцангуй цөөн гарч тохиолдох буюу ач холбогдол багатай байх хандлагатай гэж УСНББОУСЗ тэмдэглэсэн. Гэвч саналын буюу адилтгах эрхүүд нь бусад байгууллагад уг улсын секторын байгууллага хяналт тогтоох гол арга зам байж болох учраас тусгай бүтэц бүхий байгууллагын тодорхойлолтонд саналын буюу адилтгах эрхийг харгалзан тусгах нь тохиромжтой хэвээр байгаа гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Байгууллагыг хянах уламжлалт тогтсон арга зам нь тухайн байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд голлох хүчин зүйл биш бөгөөд улсын секторт гарч тохиолдох өргөн хүрээтэй нөхцөл байдлыг хамардаг тохиолдолд тусгай бүтэц бүхий байгууллага үүсэж болно гэдгийг онцлон тэмдэглэхийн тулд УСНББОУСЗ нь уг тусгай бүтэц бүхий байгууллагын тодорхойлолтыг засварлан өөрчлөхөөр шийдвэрлэсэн.
- ДҮ5. Захиргааны зохицуулалт болон дүрэм журмын заалтыг (хууль тогтоомжийг) УСНББОУСЗ нь улсын секторын олон байгууллагуудын хувьд хяналтыг тодорхойлж болох нийтлэг арга хэрэгсэл гэж тодорхойлсон. Иймээс УСНББОУСЗ нь тусгай бүтэц бүхий байгууллагын тодорхойлолтод тусгасан “адилтгах эрх” хэллэг нь захиргааны зохицуулалт болон хууль тогтоомжийн заалтыг агуулна гэсэн байр суурьтай байдаг. Иймээс захиргааны зохицуулалт буюу хууль тогтоомж нь тухайн байгууллагын хяналтыг тодорхойлоход голлох хүчин зүйл биш байх байгууллагууд нь тусгай бүтэц бүхий байгууллага болохгүй гэдгийг СТ-д илэрхийлсэн. Тусгай бүтэц бүхий байгууллагуудаас шаардаж буй тодруулгууд нь тохиромжтой боловч ач холбогдолтой байхын тулд эдгээр нь цөөн ангийн байгууллагуудад голлон чиглэгдэх (СТОУС 12-ыг мөрдөж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд НББОУСЗ-ийн тавих шаардлагуудын санаа зорилготой нийцэх) шаардлагатай гэж УСНББОУСЗ үзсэн.
- ДҮ6. Тусгай бүтэц бүхий байгууллагын тодорхойлолт нь зөвшөөрөгдөөгүй арга замаар буюу хууль зөрчсөн байдлаар үйл ажиллагаагаа эрхлэн явуулахыг байгууллагад санал болгож буй мэтээр ойлгогдож болохоор байна гэж СТ 52-д хариулт өгсөн зарим хүмүүс санаа зовж байсан. Энэ бол түүний сэдэл төлөвлөгөө биш гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн бөгөөд аливаа

тодруулга шаардлагатай эсэхийг тогтоохын тулд тусгай бүтэц бүхий байгууллагын тодорхойлолтыг дахин хянаж үзсэн. Тусгай бүтэц бүхий байгууллага нь холбогдох дүрэм журам буюу захиргааны зохицуулалтыг даган мөрдөх шаардлагагүй гэсэн санааг уг тодорхойлолт илэрхийлээгүй байна гэж УСНББОУСЗ мэдэгдсэн. Харин уг тодорхойлолт нь ижил төсөөтэй байгууллагуудыг үүсгэн байгуулахад нийтлэг ашигладаг зохицуулалтаас өөр зохицуулалтын дагуу байгууллагуудын жижиг бүлгийг үүсгэн байгуулах боломжийг олгодог.

#### **Хөрөнгө оруулалтын байгууллагууд (27-34-р параграф)**

ДҮ7. УСНББОУСЗ нь СТОУС 12-аар шаардсан хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжүүдийн тодруулгыг харгалзан үзсэн бөгөөд тэдгээр тодруулга нь улсын секторт мөн тохиромжтой гэж дүгнэсэн. УСНББОУС 35-д заасан шаардлагуудын үр дүнд хөрөнгө оруулалтын байгууллагууд бүхий улсын секторын ихэнх байгууллагууд нь ийм тодруулга хийх шаардлагатай болно гэж УСНББОУСЗ тэмдэглэсэн.

ДҮ8. Хөрөнгө оруулалтын бус, хяналт тавигч байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллагуудыг бодит үнэ цэнээр тайлагнахдаа аливаа нэмэлт тодруулга хийхийг түүнээс шаардах эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Хөрөнгө оруулалтын байгууллагуудтай холбоотойгоор шаардсан тодруулга нь зохистой бөгөөд хөрөнгө оруулалтын байгууллагууд бүхий хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд үүнийг мөн тусган оруулах хэрэгтэй гэж УСНББОУСЗ үзсэн.

#### **Тоогоор илэрхийлэх боломжгүй өмчлөлийн хувь оролцоо (49 ба 50-р параграф)**

ДҮ9. УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ын цар хүрээг “тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоо”-гоор хязгаарладаг. Хариулт өгсөн хүмүүс нь энэхүү саналыг дэмжсэн боловч бусад байгууллагууд дахь тухайн байгууллагын тоогоор илэрхийлэх боломжгүй өмчлөлийн хувь оролцооны талаархи мэдээллийг тодруулах нь тохиромжтой эсэхийг харгалзан үзсэн гэдгийг УСНББОУС тэмдэглэсэн. Тоогоор илэрхийлэх боломжгүй өмчлөлийн хувь оролцооны талаархи мэдээллийн тодруулга хийхийг энэ Стандартад шаардахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн.

#### **Худалдан борлуулах зорилгоор олж эзэмшсэн хяналтын хувь оролцоо (50-57-р параграф)**

ДҮ10. СТ 52-д хариулт өгсөн зарим хүмүүс нь түр зуурын хяналтын талаар (СТОУС 5, *Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа*-нд үндэслэн стандарт боловсруулах эсвэл энэхүү Стандартад тодруулга нэмж оруулах замаар) тодруулга хийхийг УСНББОУСЗ шаардах хэрэгтэй гэсэн санал гаргасан. УСНББОУСЗ нь борлуулах зорилгоор эзэмшиж байгаа, хяналтанд буй бүх хөрөнгө оруулалтын хувьд тодруулга хийхийг шаардах уг санааг харгалзан үзсэн

бөгөөд хэт өргөн хүрээтэй гэсэн үндэслэлээр хүлээн зөвшөөрөөгүй. Гэвч хязгаарлагдмал хугацаанд эзэмших санаа зорилго бүхий хяналтын хувь оролцооны талаархи зарим тодруулга нь хэрэглэгчдийн сонирхолыг татаж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Жишээлбэл; байгууллагын алдаа, дутагдлын үр дагавраас урьдчилан сэргийлэх хөндлөнгийн оролцооны, эсвэл бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд дараа нь дахин түгээн хуваарилах үүднээс худалдан авсан байгууллагуудын талаархи мэдээллийг хэрэглэгчид нь сонирхож болно гэдгийг УСНББОУСЗ харгалзсан үзсэн. Хяналтын хувь оролцоог анх худалдан авах үед болон тухайн тайлант үеийн эцсийн аль алины хувьд тэрхүү хувь оролцоог худалдан борлуулах идэвхитэй сэдэл төлөвлөгөөтэй байх тийм тохиолдолд УСНББОУСЗ-ийн зорилго нь уг хяналтын хувь оролцооны талаархи мэдээллийн тодруулга хийхийг шаардах явдал гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

- ДҮ11. Тодруулга хийх мэдээллийг харгалзан үзэх үедээ УСНББОУСЗ нь уг шаардлага мөн чанарын хувьд ерөнхий байвал зохино гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Хяналтын хувь оролцоог олж эзэмших эсвэл худалдан борлуулах нөхцөл байдал нь ихээхэн харилцан адилгүй байж болно (жишээлбэл; баталгаа гаргах замаар хяналтын хувь оролцоог олж эзэмшиж болно) гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Түүнчлэн, байгууллагууд нь ийм хяналтын хувь оролцоо үүсгэж болох ажил гүйлгээ буюу үйл явдлын талаархи мэдээллээр хангахыг хүсэж болох бөгөөд УСНББОУСЗ нь уг бэлтгэх мэдээллийн төрлүүдийн талаар шаардлагагүй зааварчилгаа өгөхийг хүсээгүй. Иймээс хэрэглэгчид нь ийм хяналтын хувь оролцоог нэгтгэснээр тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг уг санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтэнд үзүүлэх нөлөөг харгалзан лавлагаа болгосноор ойлгоход тэдэнд туслалцаа үзүүлэх тодруулга хийх шаардлага гаргахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн.
- ДҮ12. Данснаас хасалт хийх хүлээгдэж буй аргыг тухайн тайлангийн өдөр шийдээгүй, харгалзан үзэж байж болох бөгөөд уг төлөвлөгөө нь нэг тайлант үеэс нөгөө тайлант үед өөрчлөгдөж болно гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Мөн түүнчлэн, данснаас хасалтыг үе шаттайгаар хийж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Иймээс УСНББОУСЗ нь “данснаас хасах арга хандлагын одоогийн төлөв байдал”-ын талаар тодруулга хийхээр шаардахыг зөвшөөрсөн.
- ДҮ13. Хяналт нь нэг жил эсвэл хоёр жил гэх мэт тодорхой хугацаанд оршин байхаар хүлээгдэж буй тийм нөхцөл байдлаар уг тодруулгыг хязгаарлах эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь тодорхой цаг хугацаа заахгүй байхаар шийдвэрлэсэн. Хяналтын хувь оролцоо, түүнчлэн уг хувь оролцоог худалдан борлуулах идэвхитэй сэдэл төлөвлөгөөтэй хэвээр байгаа тийм нөхцөл байдлуудаар тодруулгыг хязгаарлах нь хэрэглэгчдийг хэт дэлгэрэнгүй мэдээллээр дарахгүйгээр зохих мэдээллийн ач холбогдолтой тодруулга хийх боломж бүрдүүлнэ гэж УСНББОУСЗ үзсэн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 38-д хийсэн хянан засварлалт**

ДҮ14. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (a) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## СТОУС 12-ТОЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-ыг СТОУС 12, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга* (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан, үүн дотроо 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан)-аас үндсэндээ бэлтгэсэн. Энэ Стандартыг гаргах үед УСНББОУСЗ нь СТОУС 9, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийн улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжтой байдлыг харгалзан үзээгүй байсан. Иймээс СТОУС 12 дахь СТОУС 9 гэсэн хэллэгүүдийг санхүүгийн хэрэглүүрүүдийг зохицуулдаг УСНББОУС-уудын нэрээр орлуулан хэрэглэсэн.

УСНББОУС 38 ба СТОУС 12-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 38 нь зарим тохиолдолд СТОУС 12-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 38 дахь “цэвэр хөрөнгө/өмч”, “эдийн засгийн нэгдмэл байгууллага”, “хяналт тавигч байгууллага”, “хяналтанд буй байгууллага”, “орлого” /revenue/ гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. СТОУС 12 дахь адилтгах нэр томъёо нь “өмч”, “групп”, “толгой компани”, “охин компани”, “орлого” /income/ юм.
- УСНББОУС 38-д дурдсан, тусгай бүтэц бүхий байгууллагын тодорхойлолт нь улсын секторт хяналтыг олж авч болох янз бүрийн арга замуудыг илэрхийлсэн.
- Хөрөнгө оруулалтын байгууллагыг хянадаг боловч өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш байх, хяналт тавигч байгууллага нь нэгтгэдэггүй, хөрөнгө оруулалтын байгууллагуудын талаархи мэдээллийг тодруулахыг УСНББОУС 38-аар шаарддаг. Ийм хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагуудыг нэгтгэхийг СТОУС 10-аар шаардсан байдаг тул хөрөнгө оруулалтын байгууллагыг хянадаг боловч өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш байх хяналт тавигч байгууллага нь ийм тодруулга хийхийг СТОУС 12-оор шаарддаггүй.
- УСНББОУС 38 нь тоогоор илэрхийлэх боломжгүй өмчлөлийн хувь оролцооны талаархи мэдээллийн тодруулга хийхийг шаарддаг. Ийм тодруулгыг СТОУС 12-д тусгайлан заагаагүй.
- Худалдан борлуулах санаа зорилготойгоор олж эзэмшсэн ба энэ зорилгоор эзэмшсэн хэвээр байгаа байгууллагууд дахь хувь оролцооны талаархи мэдээллийг тодруулахыг УСНББОУС 38-аар шаардсан байдаг. Ийм тодруулгыг СТОУС 12-д тусгайлан заагаагүй. Харин СТОУС 5, *Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа* нь борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн талаар тодруулга хийхийг шаарддаг.



## УСНББОУС 39–АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 19, *Ажилтны Тэтгэмж*-ээс үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 19-өөс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

**УСНББОУС 39-АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ**

**УСНББОУС-ын түүх**

*Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.*

## УСНББОУС 39–АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

## АГУУЛГА

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-7
Тодорхойлолт	8
Ажилтны богино хугацааны тэтгэмж	9-25
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	11-24
Тодруулга	25
Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж - Тогтоосон шимтгэлийн хөтөлбөр	26-51
ба тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн хоорондох ялгаатай талууд	
Олон ажил олгогчийн хөтөлбөр	32-39
Ерөнхий хяналтанд буй байгууллагуудад эрсдлийг хуваах	40-43
тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр	
Улсын хөтөлбөр	44-47
Даатгуулсан тэтгэмж	48-51
Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж - Тогтоосон шимтгэлийн хөтөлбөр	52-56
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	53-54
Тодруулга	55-56
Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж - Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр	57-154
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	58-67
Өнгөрсөн үйлчилгээний зардал ба барагдуулалтаас үүссэн олз,	101-114
гарз	
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт – Хөтөлбөрийн хөрөнгө	115-121
Тогтоосон тэтгэмжийн зардлын бүрэлдэхүүн хэсгүүд	122-132
Толилуулга	133-136
Тодруулга	137-154
Ажилтны урт хугацааны бусад тэтгэмж	155-161
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	158-160
Тодруулга	161
Ажлаас халагдалтын тэтгэмж	162-174
Хүлээн зөвшөөрөлт	168-171
Хэмжилт	172-173
Тодруулга	174
Шилжилтийн нөхцөл	175
Хүчин төгөлдөр болох хугацаа	176-177
УСНББОУС 25 (2008 он)-аас татгалзах ба орлуулах	178
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
НББОУС 19-тэй харьцуулалт	

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг 1-178-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 39-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь ажилтны тэтгэмжийн нягтлан бодох бүртгэл ба тодруулгыг тодорхойлоход оршино. Энэ Стандарт нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрөхийг байгууллагаас шаарддаг. Үүнд:
  - (а) Ирээдүйд төлөгдөх ажилтны тэтгэмжийн хариу болгон ажилтан үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд өр төлбөр; ба
  - (б) Ажилтны тэтгэмжийн хариу болгон ажилтны үзүүлсэн үйлчилгээнээс бий болох эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тухайн байгууллага ашигласан тохиолдолд зардал.

## Цар хүрээ

2. **Ажил олгогч нь хувьцаанд суурилсан ажил гүйлгээнээс бусад (хувьцаанд суурилсан ажил гүйлгээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг үзнэ үү), ажилтны бүх тэтгэмжийн тайлагналын хувьд энэ Стандартыг мөрдөнө.**
3. Энэ Стандарт нь ажилтны тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн хөтөлбөрийн тайлагналд хамаарахгүй (ажилтны тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн хөтөлбөрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг үзнэ үү). Нийгмийн хамгааллын холимог хөтөлбөрийн дагуу үзүүлэх ба улсын секторын байгууллагуудын ажилтнуудын буюу хуучин ажилтнуудын үзүүлсэн үйлчилгээний хариу төлбөр болохгүй тийм тэтгэмжийг энэ Стандартаар зохицуулахгүй.
4. Энэ Стандартыг даган мөрдөх ажилтны тэтгэмж нь дараах байдлаар олгох тэтгэмжүүдийг агуулсан байна:
  - (а) Байгууллага ба хувь хүн ажилтнууд, ажилтнуудын бүлэг буюу тэдний төлөөлөгчдийн хоорондох албан ёсны хөтөлбөр эсвэл бусад албан ёсны гэрээ хэлцлийн дагуу;
  - (б) Үндэсний, мужийн, салбарын буюу олон-ажил олгогчийн бусад хөтөлбөрт эсвэл нийгмийн хамгааллын холимог хөтөлбөрт шимтгэл төлөхийг байгууллагуудаас шаардах хуулийн шаардлага болон салбарын хөтөлбөр арга хэмжээний дагуу;
  - (в) Гэрээний бус үүрэг үүсэхэд хүргэдэг албан бус практикын дагуу. Албан бус практик нь тухайн байгууллага ажилтны тэтгэмжийг төлөх ба үүнээс өөр бодит сонголтгүй болох тийм гэрээний бус үүргийг үүсгэдэг. Байгууллагын уг албан бус практикын өөрчлөлт нь ажилтнуудтай тогтоосон түүний харилцаанд хүлээн зөвшөөрөх боломжгүй хохирол учруулахаар байх нь гэрээний бус үүргийн жишээ болно.

5. Ажилтны тэтгэмжид дараах зүйлс хамаарна:
- (а) Ажилтан нь холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор бүхэлдээ төлөгдөж барагдахаар хүлээгдэж буй доор дурдсан гэх мэт ажилтны богино хугацааны тэтгэмж:
    - (i) Цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл;
    - (ii) Ээлжийн амралтын цалин, өвчтэй хугацааны тэтгэмж;
    - (iii) Ашиг хуваалт ба шагнал урамшуулал;
    - (iv) Одоо байгаа ажилтнуудад олгодог мөнгөн бус тэтгэмж (эрүүл мэндийн үйлчилгээ, орон байр, машин унаа, үнэгүй эсвэл хөнгөлөлттэй бараа, үйлчилгээ гэх мэт);
  - (б) Доор дурдсан гэх мэт ажил эрхлэлтийн дараах тэтгэмж:
    - (i) Тэтгэвэрт гарах үеийн тэтгэмж (жишээлбэл; тэтгэвэр, түүнчлэн тэтгэвэрт гарах үед бөөн дүнгээр олгох төлбөр);
    - (ii) Ажил эрхлэлтийн дараах амь даатгал болон эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт ажил эрхлэлтийн дараах бусад тэтгэмж;
  - (в) Доор дурдсан гэх мэт ажилтны урт хугацааны бусад тэтгэмж:
    - (i) Удаан хугацаагаар ажилласны амралт буюу саббатикал амралт<sup>1</sup> гэх мэт урт хугацааны цалинтай чөлөө;
    - (ii) Ойн баярын буюу удаан хугацаанд ажилласаны бусад тэтгэмж;
    - (iii) Удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж;
  - (г) Ажлаас халагдалтын тэтгэмж.
6. Ажилтны тэтгэмж нь ажилтнууд эсвэл тэдний асран хамгаалуулагчдад олгох тэтгэмжүүдээс бүрдэх бөгөөд тухайн ажилтнууд, тэдний эхнэр нөхөр, хүүхэд буюу асран хамгаалуулагч бусад хүмүүс, эсвэл даатгалын компани гэх мэт бусад талуудын аль нэгэнд шууд төлөх (эсвэл бараа, үйлчилгээ нийлүүлэх) замаар тэтгэмжийг барагдуулж болно.
7. Ажилтан нь байгууллагад бүтэн цагаар, хагас цагаар, байнга, тогтмол бус буюу түр ажиллаж, үйлчилгээ үзүүлж болно. Энэ Стандартын зорилгын хувьд ажилтнууд гэдэгт УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-д тодорхойлсон эрх бүхий албан тушаалтнууд хамаарна.

---

<sup>1</sup> Sabbatical leave-Саббатикал амралт гэдэг нь ажлын байранд ирэхгүй боловч тухайн байгууллагадаа ажиллаж, цалин хөлс авах урт хугацааны амралт буюу завсарлагыг хэлдэг. Тухайлбал; багш эрдэмтэд нь малталт, судалгаа хийх гэх мэтээр хөдөө хээр явах эсвэл ном бичих буюу суралцах, эсвэл зүгээр л амрахаар нэг сараас нэг жил хүртэлх хугацааны цалинтай чөлөө авдаг. Зарим байгууллага нь цалин өгөхгүй, харин амьжиргааны зардалд зориулсан тэтгэмж олгодог. Ихэвчлэн 7 жил тутамд нэг жилийн хугацаатай ийм амралт авах эрхтэй болдог байна. Ред Ч.Д.

## Тодорхойлолт

8. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

### **Ажилтны тэтгэмжүүдийн тодорхойлолт**

Ажилтны тэтгэмж гэдэг нь ажилтнуудын үзүүлсэн үйлчилгээний хариуд буюу ажлаас халагдалтын хувьд байгууллагаас олгож буй бүх бүх төрлийн төлбөр буюу урамшуулал юм.

Ажилтны богино хугацааны тэтгэмж гэдэг нь уг ажилтан холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор бүрэн барагдуулахаар хүлээгдэж буй ажилтны тэтгэмж (ажлаас халагдалтын тэтгэмжээс бусад) юм.

Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж гэдэг нь ажилтны ажил эрхлэлт дуусгавар болсны дараа төлөгдөх тэтгэмж (ажлаас халагдалтын тэтгэмж ба ажилтны богино хугацааны тэтгэмжээс бусад) юм.

Ажилтны үрт хугацааны бусад тэтгэмж гэдэг нь ажилтны богино хугацааны тэтгэмж, ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болон ажлаас халагдалтын тэтгэмжээс бусад тэтгэмжийг хэлнэ.

Ажлаас халагдалтын тэтгэмж гэдэг нь дараах зүйлсийн аль нэгний үр дүнд ажилтны ажил эрхлэлтийг дуусгавар болгосны хариуд түүнд олгох тэтгэмжийг хэлнэ:

- (а) Тэтгэвэрт гарах хэвийн хугацаанаас өмнө ажилтны ажил эрхлэлтийг дуусгавар болгох тухайн байгууллагын шийдвэр; эсвэл
- (б) Ажил эрхлэлтийг дуусгавар болгосны хариуд тэтгэмж олгох саналыг хүлээн зөвшөөрсөн ажилтны шийдвэр.

### **Хөтөлбөрийн ангилалтай холбоотой тодорхойлолт**

Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр гэдэг нь байгууллага нэг буюу хэд хэдэн ажилтанд ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийг олгох албан буюу албан бус тохиролцоо юм.

Тогтоосон шимтгэлийн хөтөлбөр гэдэг нь ажил олгогч-байгууллага шимтгэлийг өөр тусдаа байгууллагад (сан)-д тогтмол дүнгээр төлөх бөгөөд ажилтны тухайн тайлант үед болон өмнөх тайлант үеүдэд үзүүлсэн үйлчилгээтэй холбоотойгоор тэрхүү ажилтны бүх тэтгэмжийг төлөхөд уг сан хангалттай хөрөнгөгүй байлаа гэхэд тухайн ажил олгогч-байгууллага цаашид нэмэлт шимтгэл төлөх хуулийн эсвэл гэрээний бус үүрэг хүлээдэггүй тийм ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр юм.

Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр гэдэг нь тогтоосон шимтгэлийн хөтөлбөрөөс бусад, ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр юм.

Олон ажил олгогчийн хөтөлбөр гэдэг нь дараах үүрэг бүхий тогтоосон шимтгэлийн хөтөлбөр (улсын хөтөлбөрөөс бусад) эсвэл тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр (улсын хөтөлбөрөөс бусад) юм:

- (a) Ерөнхий хяналтан дор байдаггүй, өөр өөр байгууллагуудаас шимтгэл байдлаар оруулсан хөрөнгийг нэгтгэдэг; ба
- (б) Ажилтнууд нь аль байгууллагад ажиллаж байгаагаас үл хамааран тодорхойлсон, шимтгэл ба тэтгэмжийн түвшинд үндэслэн нэгээс олон байгууллагын ажилтнуудад тэтгэмжийг олгохын тулд тэдгээр хөрөнгийг ашигладаг.

Улсын хөтөлбөр гэдэг нь хууль тогтоомжинд заасан, эдийн засгийн ангиллууд дахь бүх байгууллагуудад зориулсан, олон ажил олгогчийн хөтөлбөртэй адилаар үйл ажиллагаа явуулахаар хууль тогтоомжийн дагуу байгуулсан хөтөлбөр юм.

**Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-тэй холбоотой тодорхойлолт**

Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө) гэдэг нь тогтоосон тэтгэмжийн цэвэр хөрөнгийг тухайн хөтөлбөрийн хөрөнгийн дээд хязгаарт багтаан хязгаарласны аливаа үр нөлөөний хувьд тохируулагдсан уг хөтөлбөрийн дутагдал (эсвэл илүүдэл) юм.

Дутагдал эсвэл илүүдэл гэдэг нь:

- (a) Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнээс
- (б) Уг хөтөлбөрийн хөрөнгө (хэрэв байгаа бол)-ийн бодит үнэ цэнийг хассан дүнг хэлнэ.

Хөрөнгийн дээд хязгаар гэдэг нь тухайн хөтөлбөрөөс буцаан олгох эсвэл уг хөтөлбөрт төлөх ирээдүйн шимтгэлийг бууруулах хэлбэрээр бий болох аливаа эдийн засгийн үр өгөөжийн өнөөгийн үнэ цэнэ юм.

Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ гэдэг нь тухайн тайлант үед болон өмнөх тайлант үеүдэд ажилтны үзүүлсэн үйлчилгээний үр дүнд үүссэн үүргийг барагдуулахад шаардагдахаар хүлээгдэж буй ирээдүйн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ бөгөөд хөтөлбөрийн аливаа хөрөнгийг хасаагүй дүн байдаг.

Хөтөлбөрийн хөрөнгө нь дараах зүйлсээс бүрдэнэ:

- (a) Ажилтны урт хугацааны тэтгэмжийн сангийн эзэмшиж буй хөрөнгө; ба
- (б) Шалгуур хангах даатгалын гэрээнүүд.



**Ажилтны урт хугацааны тэтгэмжийн сангийн эзэмшиж буй хөрөнгө гэдэг нь дараах хөрөнгүүдийг (тайлагнагч байгууллагын гаргасан үл шилжүүлэгдэх санхүүгийн хэрэглүүрээс бусад) хэлнэ:**

- (a) Тухайн тайлагнагч байгууллагаас хууль эрх зүйн хувьд тусгаар бөгөөд зөвхөн ажилтны тэтгэмжийг төлөх буюу санхүүжүүлэхийн тулд оршин буй тийм байгууллагын (сангийн) эзэмшиж байгаа;
- (б) Зөвхөн ажилтны тэтгэмжийг төлөх буюу санхүүжүүлэхэд ашиглагдах боломжтой ба тухайн тайлагнагч байгууллагын (дампуурлын үед ч гэсэн) зээлдүүлэгчдэд төлбөр хийхэд ашиглагдах боломжгүй бөгөөд доор дурдсан аль нэг тохиолдлоос бусад үед тайлагнагч байгууллагад буцаан олгогдохгүй:
  - (i) Сангийн үлдэгдэл хөрөнгө нь тухайн хөтөлбөрийн эсвэл тайлагнагч байгууллагын ажилтны холбогдох бүх тэтгэмжийн үүргийг барагдуулахад хангалттай байх; эсвэл
  - (ii) Ажилтны тэтгэмжийг аль хэдийн төлсөн тайлагнагч байгууллагад тэрхүү төлбөрийг нөхөн олгохын тулд хөрөнгийг уг байгууллагад буцаах.

**Шалгуур хангах даатгалын гэрээ гэдэг нь тайлагнагч байгууллагын хувьд холбоотой тал (УСНББОУС 20-д тодорхойлсноор) биш байх тийм даатгагчтай байгуулсан даатгалын гэрээ<sup>2</sup> бөгөөд уг гэрээний орлого нь дараах шинжтэй байна:**

- (a) Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу зөвхөн ажилтны тэтгэмжийг төлөх буюу санхүүжүүлэхэд ашиглагдах;
- (б) Тухайн тайлагнагч байгууллагын (дампуурлын үед ч гэсэн) зээлдүүлэгчдэд төлбөр хийхэд ашиглагдах боломжгүй бөгөөд доор дурдсан аль нэг тохиолдлоос бусад үед тайлагнагч байгууллагад буцаан олгогдохгүй:
  - (i) Гэрээний орлого нь ажилтны холбогдох бүх тэтгэмжийн үүргийг барагдуулахад уг даатгалын гэрээний хувьд шаардлагагүй, илүүдэл хөрөнгийг илэрхийлэх; эсвэл
  - (ii) Ажилтны тэтгэмжийг аль хэдийн төлсөн тайлагнагч байгууллагад тэрхүү төлбөрийг нөхөн олгохын тулд уг орлогыг тухайн байгууллагад буцаах.

---

<sup>2</sup> Шалгуур хангах даатгалын гэрээ нь заавал даатгалын гэрээ байх албагүй юм (даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг үзнэ үү).

## **Тогтоосон тэтгэмжийн зардалтай холбоотой тодорхойлолт**

Үйлчилгээний зардал нь дараах зүйлсээс бүрддэг:

- (а) Одоогийн үйлчилгээний зардал, энэ нь тухайн тайлант үед ажилтны үзүүлсэн үйлчилгээний үр дүн болох тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийн өсөлт юм;
- (б) Өнгөрсөн үйлчилгээний зардал, энэ нь хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт (тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн нэвтрүүлэлт, хүчингүй болголт буюу өөрчлөлт) эсвэл цомхотгол (хөтөлбөрт хамрагдсан ажилтнуудын тоог тухайн байгууллага мэдэгдэхүйц цөөрүүлэлт)-ын үр дүнд ажилтны өмнөх тайлант үеүдэд үзүүлсэн үйлчилгээний хувьд төлөх тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэд гарсан өөрчлөлт юм;
- (в) Үүргийн барагдуулалтаар үүссэн аливаа олз, гарз.

Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүү гэдэг нь цаг хугацаа урсан өнгөрсний үр дүнд, тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-т тухайн тайлант үеийн туршид гарсан өөрчлөлт юм.

Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилт нь дараах зүйлсээс бүрдэнэ:

- (а) Актуар олз, гарз;
- (б) Хөтөлбөрийн хөрөнгийн өгөөж, үүнд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүнд багтсан дүнг оруулахгүй;
- (в) Хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөнд гарсан аливаа өөрчлөлт, үүнд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүнд багтсан дүнг оруулахгүй.

Актуар олз, гарз гэдэг нь дараах зүйлсийн улмаас тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэд гарсан өөрчлөлт юм:

- (а) Туршлагад үндэслэсэн тохируулга (өмнөх актуар төсөөлөл ба бодитойгоор гарч тохиолдсон зүйлийн хоорондох зөрүүгийн үр нөлөө); ба
- (б) Актуар төсөөллийн өөрчлөлтийн үр нөлөө.

Хөтөлбөрийн хөрөнгийн өгөөж гэдэг нь хөтөлбөрийн хөрөнгөөс бий болсон хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, бусад орлого, түүнчлэн уг хөтөлбөрийн хөрөнгийн хувьд хэрэгжсэн болон хэрэгжээгүй олз, гарз бөгөөд тэдгээрээс дараах зүйлсийг хассан дүн юм:

- (а) Хөтөлбөрийн хөрөнгийг удирдан зохицуулах аливаа зардал; ба
- (б) Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийг хэмжихийн тулд ашигласан актуар төсөөлөлд багтсан татвараас бусад, уг сангийн өөрийн аливаа татварын өглөг.

**Барагдуулалт** гэдэг нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу олгох бүх буюу зарим тэтгэмжийн хувьд хүлээх цаашдын бүх хуулийн эсвэл гэрээний бус үүргийг дуусгавар болгох ажил гүйлгээ, гэхдээ уг хөтөлбөрийн нөхцөлд заасан ба актуар төсөөлөлд харгалзан тусгасан, ажилтнуудад төлөх эсвэл тэдний өмнөөс төлөх тэтгэмжийн төлбөр үүнд хамаарахгүй.

### **Ажилтны богино хугацааны тэтгэмж**

9. Ажилтны богино хугацааны тэтгэмж нь ажилтнууд холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор бүхэлдээ төлөгдөж барагдахаар хүлээгдэж буй дараах гэх мэт тэтгэмжүүдийг багтаана:
- (а) Цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл;
  - (б) Ээлжийн амралтын цалин, өвчтэй хугацааны тэтгэмж;
  - (в) Ашиг хуваалт ба шагнал урамшуулал;
  - (г) Одоо байгаа ажилтнуудад олгодог мөнгөн бус тэтгэмж (эрүүл мэндийн үйлчилгээ, орон байр, машин унаа, үнэгүй эсвэл хөнгөлөлттэй бараа, үйлчилгээ гэх мэт);
10. Тэтгэмжийг барагдуулах цаг хугацааны талаархи байгууллагын хүлээлт нь түр зуур өөрчлөгдсөн бол уг байгууллага нь ажилтны богино хугацааны тэтгэмжийг дахин ангилах шаардлагагүй. Харин тэтгэмжийн шинж чанар өөрчлөгдсөн (үл хуримтлагдах тэтгэмжээс хуримтлагдах тэтгэмж болох өөрчлөлт гэх мэт) эсвэл тэтгэмжийг барагдуулах цаг хугацааны талаархи хүлээлтийн өөрчлөлт нь түр зуурын биш байвал тухайн тэтгэмж нь ажилтны богино хугацааны тэтгэмжийн тодорхойлолтыг хангасан хэвээр байгаа эсэхийг уг байгууллага харгалзан үзнэ.

### **Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт**

*Ажилтны богино хугацааны бүх төрлийн тэтгэмж*

11. Ажилтан нь нягтлан бодох бүртгэлийн тайлант үед байгууллагад үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд уг байгууллага нь тухайн үйлчилгээний хариуд төлөхөөр хүлээгдэж буй ажилтны богино хугацааны тэтгэмжүүдийг тэдгээрийн дискаунтчлаагүй дүнгээр дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:
- (а) Аль хэдийн төлсөн дүнг хассаны дараа, өр төлбөр (хуримтлагдсан зардал) байдлаар. Хэрэв аль хэдийн төлсөн дүн нь тухайн тэтгэмжийн дискаунтчлаагүй дүнгээс илүү байвал уг

урьдчилсан төлбөр нь тухайлбал, ирээдүйн төлбөрүүдийн бууралт эсвэл мөнгөн буцаан олголт болох тэр хэмжээгээр байгууллага нь илүү төлөлтийг хөрөнгө (урьдчилж төлсөн зардал) гэж хүлээн зөвшөөрнө.

- (б) Өөр бусад Стандарт нь уг тэтгэмжийг хөрөнгийн өртөгт оруулахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд (тухайлбал, УСНББОУС 12, *Бараа Материал* ба УСНББОУС 17 *Үндсэн Хөрөнгө*-ийг үзнэ үү) зардал байдлаар.

12. Цалинтай чөлөө, ашиг хуваалт, шагналын хөтөлбөр хэлбэрээр олгох ажилтны богино хугацааны тэтгэмжүүдэд 11-р параграфыг тухайн байгууллага хэрхэн даган мөрдөхийг 13, 16, 19-р параграфуудад тайлбарласан.

*Богино хугацааны цалинтай чөлөө*

13. Цалинтай чөлөө хэлбэрээр олгох ажилтны богино хугацааны тэтгэмжийн хүлээгдэж буй зардлыг байгууллага нь 11-р параграфын дагуу дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- (а) Хуримтлагдах цалинтай чөлөөний хувьд, ажилтнууд нь ирээдүйд цалинтай чөлөө авах өөрсдийн эрхийг нэмэгдүүлэх үйлчилгээг үзүүлсэн үед; ба
- (б) Үл хуримтлагдах цалинтай чөлөөний хувьд, чөлөө авсан үед.

14. Ээлжийн амралт авах, өвчлөх ба хөдөлмөрийн чадвар түр алдах, эцэг/эх болох, шүүх ажиллагаанд оролцох, цэргийн алба хаах гэх мэт янз бүрийн шалтгаанаар чөлөө авах үед байгууллага нь ажилтнуудад энэ хугацааны цалинг олгож болно. Цалинтай чөлөө авах эрхийг хоёр ангилдаг:

- (а) Хуримтлагдах; ба
- (б) Үл хуримтлагдах.

15. Хуримтлагдах цалинтай чөлөө нь дараагийн үеүдэд шилжүүлэгдэх чөлөө бөгөөд тухайн тайлант үеийн эрхээ бүрэн ашиглаагүй бол ирээдүйн тайлант үеүдэд үүнийг ашиглаж болох юм. Хуримтлагдах цалинтай чөлөө нь баталгаатай (өөрөөр хэлбэл, уг байгууллагаас гарахдаа ашиглаагүй эрхийн хувьд мөнгөн төлбөр авах эрхийг ажилтнуудад олгодог) эсвэл баталгаагүй (уг байгууллагаас гарахдаа ашиглаагүй эрхийн хувьд мөнгөн төлбөр авах эрхийг ажилтнуудад олгодоггүй) байж болно. Ажилтнууд нь ирээдүйд цалинтай чөлөө авах өөрсдийн эрхийг нэмэгдүүлэх үйлчилгээг үзүүлснээр үүрэг үүсдэг. Цалинтай чөлөө нь баталгаагүй бөгөөд ажилтнууд уг хуримтлагдсан, баталгаагүй эрхээ ашиглахаас өмнө, ажлаас гарах боломжит байдал нь үүргийн хэмжилтэнд нөлөөлөх байлаа ч гэсэн тухайн үүрэг үүсэх бөгөөд түүнийг хүлээн зөвшөөрнө.

16. Хуримтлагдах цалинтай чөлөөний хүлээгдэж буй зардлыг байгууллага нь тухайн тайлант үеийн эцэст хуримтлагдсан, уг

**ашиглагдаагүй эрхийн үр дүнд өөрийн төлөхөөр хүлээгдэж буй нэмэлт дүнгээр хэмжинэ.**

17. Өмнөх параграфт дурдсан арга нь уг тэтгэмж хуримтлагдана гэсэн зөвхөн тийм үндэслэлээр үүсэхээр хүлээгдэж буй нэмэлт төлбөрийн дүнгээр тухайн үүргийг хэмждэг. Олон тохиолдолд байгууллага нь ашиглаагүй цалинтай чөлөөний хувьд материаллаг үүрэггүй гэдгийг тогтоохын тулд дэлгэрэнгүй тооцоолол хийх шаардлагагүй байж болно. Жишээлбэл; өвчтэй хугацааны ашиглаагүй тэтгэмжийг жилийн амралтын цалинтай адилтган авч үзэж болно гэсэн албан буюу албан бус ойлголт байгаа зөвхөн тийм тохиолдолд өвчний тэтгэмжийн үүрэг нь материаллаг дүнтэй байх магадлалтай юм.
18. Үл хуримтлагдах цалинтай чөлөөг дараагийн тайлант үед шилжүүлдэггүй: хэрэв тухайн тайлант үеийн эрхийг бүрэн ашиглаагүй бөгөөд байгууллагаас гарах үед тэрхүү ашиглаагүй эрхийн хариуд мөнгөн төлбөр авах эрхийг ажилтнуудад олгодоггүй бол уг эрх дуусах юм. Үл хуримтлагдах цалинтай чөлөө нь өвчтэй байх үеийн цалинтай чөлөө (өмнөх ашиглаагүй эрх нь ирээдүйн эрхийг нэмэгдүүлэхгүй байх хэмжээгээр), эцэг/эх болох үеийн чөлөө, шүүх ажиллагаанд оролцох буюу цэргийн алба хаах үеийн цалинтай чөлөөний хувьд нийтлэг байдаг. Ажилтны үйлчилгээ нь тэтгэмжийн дүнг нэмэгдүүлэхгүй учраас байгууллага нь чөлөө авах хүртэл өр төлбөр буюу зардлыг хүлээн зөвшөөрөхгүй.

*Ашиг хуваалт ба шагналын хөтөлбөр*

19. **Байгууллага нь зөвхөн дараах тохиолдолд ашиг хуваалтын болон шагналын хүлээгдэж буй зардлыг 11-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Тухайн байгууллага нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд ийм төлбөрийг төлөх хуулийн эсвэл гэрээний бус одоогийн үүрэгтэй байх; ба**
- (б) **Уг үүргийн дүнг найдвартай тооцоолж чадах.**

**Байгууллага нь тухайн төлбөрийг хийхээс өөр бодит сонголтгүй зөвхөн тийм тохиолдолд одоогийн үүрэг оршин байх юм.**

20. Улсын секторын хувьд зарим байгууллага нь үйлчилгээ үзүүлэх зорилтууд буюу санхүүгийн гүйцэтгэлийн төлөв байдалтай холбоотой шагналын хөтөлбөртэй байдаг. Ийм хөтөлбөрийн дагуу, ажилтнууд нь тухайн байгууллагын буюу түүний сегментийн зорилтуудын биелэлтэнд өөрсдийн оруулсан хувь нэмрийн үнэлгээнээс хамааран тусгайлан тогтоосон дүнг хүлээн авдаг. Хувь хүн тус бүрээр биш, харин тодорхой сегментийн бүх буюу зарим ажилтнуудын хувьд гүйцэтгэлийг үнэлдэг гэх мэт зарим тохиолдолд ийм хөтөлбөр нь ажилтнуудын бүлэгт зориулагдсан байж болно. Улсын секторын байгууллагуудын зорилгоос хамааран, ашиг хуваах хөтөлбөр нь ашгийн төлөөх аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад улсын секторт нийтлэг бус байдаг. Гэвч энэ нь улсын секторын байгууллагуудын

худалдаа арилжааны сууриар үйл ажиллагаагаа явуулдаг тэдгээр сегментүүдийн хувьд ажилтны урамшууллын нэг төлөв байдал байх магадлалтай юм. Улсын секторын зарим байгууллагууд нь ашиг хуваах схемийг хэрэгжүүлдэггүй боловч орлогын эх үүсвэр бүрдүүлэлт, төсвийн зорилтуудын биелэлт гэх мэт санхүүгийн шинжтэй хэмжүүрээр гүйцэтгэлийг үнэлдэг байж болох юм. Зарим шагналын хөтөлбөр нь тухайн тайлант үеийн эцэс болохоос өмнө уг байгууллагаас гарсан боловч тэрхүү тайлант үед ажил эрхлэлтийн үйлчилгээ үзүүлж байсан бүх ажилтанд төлбөр олгодог байж болно. Харин шагналын өөр бусад хөтөлбөрийн дагуу ажилтнууд нь тухайн тогтоосон хугацаанд тус байгууллагад ажилласан хэвээр байх зөвхөн тийм тохиолдолд төлбөр авдаг, тухайлбал; ажилтнууд нь тухайн тайлант үед бүхэлд нь ажиллаж, үйлчилгээ үзүүлэх шаардлага тавьдаг. Ажилтан нь тухайн тогтоосон хугацааны эцэс хүртэл ажилласан хэвээр байх тохиолдолд түүнд төлөгдөх дүнг нэмэгдүүлэх үйлчилгээг тэрээр үзүүлэхийн хэрээр ийм хөтөлбөр нь гэрээний бус үүрэгтэй болно. Ийм гэрээний бус үүргийн хэмжилт нь зарим ажилтнууд уг ашиг хуваалтын төлбөрийг авахгүйгээр ажлаасаа гарч болох тийм боломжит байдлыг тусгадаг. Байгууллага нь гүйцэтгэлд суурилсан төлбөр, шагналын төлбөр, ашиг хуваалтын төлбөрийн хүлээгдэж буй зардлыг хүлээн зөвшөөрөхийн өмнө хангагдах ёстой цаашдын нөхцлүүдийг 22-р параграфт дурдсан.

21. Байгууллага нь шагнал олгох хуулийн үүрэггүй байж болно. Гэвч байгууллага нь зарим тохиолдолд шагнал олгодог тийм практик тогтсон байдаг. Ийм тохиолдолд байгууллага нь шагнал олгохоос өөр бодит сонголтгүй тул гэрээний бус үүрэг хүлээнэ. Уг гэрээний бус үүргийн хэмжилт нь зарим ажилтан шагнал авахгүйгээр ажлаас гарч болох боломжит байдлыг тусгадаг.
22. Байгууллага нь гүйцэтгэлд суурилсан төлбөрийн схем, шагналын хөтөлбөр, ашиг хуваалтын схемийн дагуу хүлээх өөрийн хуулийн эсвэл гэрээний бус үүргийг зөвхөн дараах тохиолдолд найдвартай тооцоолж чадна:
  - (а) Тухайн хөтөлбөрийн албан ёсны нөхцөл нь тэтгэмжийн дүнг тодорхойлох томъёог агуулсан байх;
  - (б) Байгууллага нь санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө тухайн төлөх дүнг тодорхойлдог байх; эсвэл
  - (в) Өмнөх практик нь уг байгууллагын гэрээний бус үүргийн дүнгийн талаархи тодорхой нотолгоогоор хангадаг байх.
23. Ашиг хуваалт болон шагналын хөтөлбөрийн дагуу хүлээх үүрэг нь тухайн байгууллагын эзэдтэй хийсэн ажил гүйлгээнээс биш, харин ажилтны үзүүлсэн үйлчилгээнээс бий болдог. Иймээс байгууллага нь ашиг хуваалт болон шагналын хөтөлбөрийн зардлыг ашгийн хуваарилалт биш, харин зардал гэж хүлээн зөвшөөрнө.
24. Ашиг хуваалт болон шагналын төлбөр нь тухайн ажилтнууд холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойшхи арван хоёр сарын дотор бүрэн төлөгдөж барагдахааргүй бол тэдгээр төлбөр нь ажилтны урт хугацааны бусад тэтгэмж болно (155-161-р параграфыг үзнэ үү).

## Тодруулга

25. Энэ Стандарт нь ажилтны богино хугацааны тэтгэмжийн талаар тусгай тодруулга хийхийг шаардаагүй боловч өөр бусад Стандарт нь ийм тодруулга хийхийг шаардаж болох юм. Тухайлбал; УСНББОУС 20 нь эрх бүхий албан тушаалтны тэтгэмжийн талаар тодруулга хийхийг шаарддаг. УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Топилуулга* нь ажилтны тэтгэмжийн зардлын талаар тодруулга хийхийг шаарддаг.

## **Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж - Тогтоосон шимтгэлийн хөтөлбөр ба тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн хоорондох ялгаатай талууд**

26. Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжид дараах гэх мэт зүйлс хамаардаг:
- (а) Тэтгэвэрт гарах үеийн тэтгэмж (жишээлбэл; тэтгэвэр, түүнчлэн тэтгэвэрт гарах үед бөөн дүнгээр олгох төлбөр); ба
  - (б) Ажил эрхлэлтийн дараах амь даатгал болон эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт ажил эрхлэлтийн дараах бусад тэтгэмж.

Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийг байгууллага олгох арга хэмжээ нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр юм. Байгууллага нь шимтгэлийг хүлээн авах ба тэтгэмжийг төлөх тэтгэврийн схем, суперанюшн<sup>3</sup> схем, тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн схем гэхмэт тусдаа байгууллага байгуулсан эсэхээс үл хамааран ийм бүх хөтөлбөр, арга хэмжээний хувьд энэхүү Стандартыг мөрдөнө.

27. Тухайн хөтөлбөрийн үндсэн нөхцөл, болзлоор илэрхийлэгдэх түүний эдийн засгийн мөн чанараас хамааран ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөр эсвэл тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр гэж ангилдаг.
28. Тогтоосон шимтгэлийн хөтөлбөрийн дагуу, тухайн байгууллагын хуулийн эсвэл гэрээний бус үүрэг нь уг санд шимтгэл хэлбэрээр оруулахаар түүний зөвшөөрсөн дүнгээр хязгаарлагддаг. Иймээс ажилтны хүлээн авах ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн дүн нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрт эсвэл даатгалын компанид уг байгууллагын (болон магадгүй, мөн ажилтны) төлсөн шимтгэл, түүнчлэн уг шимтгэлээс бий болсон хөрөнгө оруулалтын өгөөжийн дүнгээр тодорхойлогддог. Үүний үр дүнд, актуар эрсдэл (тэтгэмж нь хүлээгдэж буй дүнгээс бага байх) ба хөрөнгө оруулалтын эрсдэл (хөрөнгө оруулалт хийсэн уг хөрөнгө нь хүлээгдэж буй тэтгэмжийг төлөхөд хүрэлцэхгүй байх)-ийг үнэн хэрэгтээ ажилтан хүлээдэг.
29. Байгууллагын үүрэг нь уг санд шимтгэл хэлбэрээр оруулахаар түүний зөвшөөрсөн дүнгээр хязгаарлагдахгүй байх тохиолдлын жишээ нь тухайн

---

<sup>3</sup> Superannuation-Суперанюшн гэдэг нь өөрийн ажилтнуудад зориулан аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэн бүрдүүлсэн байгууллагын тэтгэврийн хөтөлбөр юм гэж Инвестопедиа тольд тайлбарласан байна. Ред.Ч.Д.

байгууллага дараах зүйлсийн хувьд хуулийн эсвэл гэрээний бус үүрэгтэй байх явдал юм:

- (а) Зөвхөн шимтгэлийн дүнтэй холбоотой биш бөгөөд хэрэв хөтөлбөрийн хөрөнгө нь уг хөтөлбөрийн тэтгэмжийн томъёогоор тооцсон тэтгэмжийг төлөхөд хүрэлцэхгүй байвал цаашид шимтгэл төлөхийг тухайн байгууллагаас шаардах тийм хөтөлбөрийн тэтгэмжийн томъёолол;
- (б) Хөтөлбөрийн хувьд шууд бусаар, эсвэл тусгайлан заасан шимтгэлийн өгөөжийн хувьд шууд гаргасан баталгаа; эсвэл
- (в) Гэрээний бус үүрэг үүсэхэд хүргэх тийм албан бус практик. Жишээлбэл; байгууллага нь хуулийн үүрэггүй боловч инфляцийн өсөлттэй нийцүүлэн өөрийн хуучин ажилтнуудад олгох тэтгэмжийг нэмэгдүүлдэг түүхэн туршлагатай тохиолдолд гэрээний бус үүрэг үүсэж болно.

30. Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу;

- (а) Тухайн байгууллага нь өөрийн одоогийн болон хуучин ажилтнуудад уг тохиролцсон тэтгэмжийг олгох үүрэг хүлээдэг; ба
- (б) Актуар эрсдэл (тухайн тэтгэмж нь хүлээгдэж буй дүнгээс илүү их зардалтай байх) ба хөрөнгө оруулалтын эрсдлийг үнэн хэрэгтээ байгууллага хүлээдэг. Хэрэв актуар буюу хөрөнгө оруулалтын бодит дүн нь хүлээгдэж буй дүнгээс арай муу байвал уг байгууллагын үүрэг нэмэгдэж болох юм.

31. Тогтоосон шимтгэлийн хөтөлбөр ба тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн хоорондох ялгаатай талуудыг олон ажил олгогчийн хөтөлбөр, ерөнхий хяналтанд буй байгууллагуудад эрсдлийг хуваах тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр, улсын хөтөлбөр, даатгуулсан тэтгэмж зэргийн агуулгын хүрээнд 32-51-р параграфуудад тайлбарласан.

### **Олон ажил олгогчийн хөтөлбөр**

32. **Байгууллага нь олон-ажил олгогчийн хөтөлбөрийг уг хөтөлбөрийн нөхцлийн (үүнд: албан ёсны нөхцлөөс гадна гэрээний бус үүргийн) дагуу тогтоосон шимтгэлийн хөтөлбөр эсвэл тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр гэж ангилна.**

33. **Байгууллага нь олон-ажил олгогчийн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрт оролцдог бөгөөд 34-р параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд уг байгууллага:**

- (а) **Тогтоосон тэтгэмжийн үүрэг, хөтөлбөрийн хөрөнгө, уг хөтөлбөртэй холбоотой зардал зэргийн хувьд өөрт ногдох хувь тэнцүүлсэн хэсгийг тогтоосон тэтгэмжийн аливаа бусад хөтөлбөрийг бүртгэсэнтэй ижил арга замаар тайлагнана;**



- (б) **137-150-р параграфуудаар (150(г) параграф хамаарахгүй) шаардсан мэдээллийг тодруулна.**
34. **Олон-ажил олгогчийн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд тогтоосон тэтгэмжийн нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг хэрэглэх хангалттай мэдээлэл байхгүй тохиолдолд байгууллага нь:**
- (а) **Тухайн хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөртэй адилтган үзэж, уг хөтөлбөрийг 53 ба 54-р параграфын дагуу тайлагнах;**
- (б) **150-р параграфуудаар шаардсан мэдээллийг тодруулах.**
35. Олон ажил олгогчийн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн нэг жишээ нь:
- (а) “Шаардлагатай хэмжээгээр төлөх” зарчмаар хөтөлбөрийг санхүүжүүлдэг: энэ нь уг тайлант үед төлөхөөр болсон тэтгэмжийг барагдуулахад хангалттай байхаар хүлээгдэж буй тийм түвшнээр шимтгэлийг тогтоодог; тухайн тайлант үеийн туршид олж хуримтлагдсан ирээдүйн тэтгэмжийг ирээдүйн шимтгэлээс төлнө;
- (б) Ажилтнуудын тэтгэмжийг тэдний ажилласан хугацаагаар тодорхойлох ба оролцогч байгууллагууд нь уг хөтөлбөрөөс гарах өдөр хүртэл ажилтнуудын олж хуримтлуулсан тэтгэмжийн хувьд холбогдох шимтгэлийг төлөхгүйгээр тэрхүү хөтөлбөрөөс гарах боломжгүй байдаг. Ийм хөтөлбөр нь уг байгууллагын хувьд актуар эрсдэл үүсгэдэг; хэрэв тухайн тайлант үеийн эцэс хүртэл аль хэдийн олж хуримтлуулсан тэтгэмжийн эцсийн үр дүн болох зардал нь хүлээгдэж байсан дүнгээс илүү бол уг байгууллага нь өөрийн төлөх шимтгэлийг нэмэгдүүлэх эсвэл тэтгэмжийн бууруулалтыг ажилтнуудаар зөвшөөрүүлэх шаардлагатай болно. Иймээс ийм хөтөлбөр нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болох юм.
36. Олон ажил олгогчийн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн талаар хангалттай мэдээлэл бэлэн байгаа тохиолдолд байгууллага нь тогтоосон тэтгэмжийн үүрэг, хөтөлбөрийн хөрөнгө, уг хөтөлбөртэй холбоотой ажил эрхлэлтийн зардал зэргийн хувьд өөрт ногдох хувь тэнцүүлсэн хэсгийг тогтоосон тэтгэмжийн аливаа бусад хөтөлбөрийг бүртгэсэнтэй ижил арга замаар тайлагнана. Гэвч байгууллага нь тухайн хөтөлбөрийн үндсэн санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнгийн хувьд өөрт ногдох хувь тэнцүүлсэн хэсгийг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хангалттай найдвартайгаар тодорхойлох боломжгүй байж болох юм. Дараах тохиолдолд ийм нөхцөл байдал үүсэж болно:
- (а) Тэтгэмжийн үүрэг, хөтөлбөрийн хөрөнгө болон зардлыг уг хөтөлбөрт оролцогч бие даасан байгууллагуудад хуваарилах тууштай бөгөөд найдвартай суурь байхгүйн улмаас тухайн хөтөлбөр нь өөр бусад байгууллагуудын одоогийн болон хуучин ажилтнуудтай холбоотой актуар эрсдлийг оролцогч байгууллагуудад хүлээлгэдэг.

- (б) Байгууллага нь энэ Стандартын шаардлагуудыг ханган биелүүлэхийн тулд тухайн хөтөлбөрийн талаархи хангалттай мэдээлэлтэй танилцах боломжгүй байх.

Дээрх тохиолдолд, байгууллага нь тухайн хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөртэй адилтган үзэж, тайлагнах ба 150-р параграфтаар шаардсан мэдээллийг тодруулна.

37. Хөтөлбөрийн илүүдлийг оролцогч талуудад хэрхэн хуваарилахыг (эсвэл дутагдлыг хэрхэн санхүүжүүлэхийг) тодорхойлсон гэрээ хэлцлийг уг олон ажил олгогчийн хөтөлбөр ба түүний оролцогч талуудын хооронд байгуулсан байж болно. Тухайн хөтөлбөрийг 34-р параграфт заасны дагуу тогтоосон шимтгэлийн хөтөлбөртэй адилтган үзэж тайлагнах тийм хэлцэл тохиролцоо бүхий олон ажил олгогчийн хөтөлбөрийн оролцогч тал нь уг гэрээний тохиролцооноос үүссэн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх ба холбогдох орлого, зардлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
38. Олон ажил олгогчийн хөтөлбөр нь группын захиргаа удирдлагын хөтөлбөрөөс ялгаатай юм. Группын захиргаа удирдлагын хөтөлбөр нь тус тусдаа нэг ажил олгогчдын хөтөлбөрүүдийн энгийн нийлүүлэлт бөгөөд оролцогч ажил олгогч нар нь хөрөнгө оруулалтын зорилгоор өөрсдийн хөрөнгийг нийлүүлэх ба захиргаа удирдлагын зардлыг бууруулах боломжтой болдог. Харин өөр өөр ажил олгогч нар нь зөвхөн өөрсдийн ажилтнуудын тэтгэмжийг хариуцах тул нэхэмжлэлийг салгаж тусгаарладаг. Группын захиргаа удирдлагын хөтөлбөрийг нэг ажил олгогчийн аливаа бусад хөтөлбөртэй ижил арга замаар бүртгэж, тайлагнахад зориулсан мэдээлэл шууд бэлэн байдаг бөгөөд бусад байгууллагуудын одоогийн болон хуучин ажилтнуудтай холбоотой актуар эрсдлийг тухайн оролцогч байгууллагууд хүлээдэггүй тул группын захиргаа удирдлагын хөтөлбөрийн хувьд нягтлан бодох бүртгэлийн тусгайлан анхаарах асуудлууд байдаггүй. Энэ Стандартад заасан тодорхойлолтын дагуу байгууллага нь группын захиргаа удирдлагын хөтөлбөрийг уг хөтөлбөрийн нөхцлүүдийн (үүн дотроо, албан ёсны нөхцлөөс гадна аливаа гэрээний бус үүргийн) дагуу тогтоосон шимтгэлийн хөтөлбөр эсвэл тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр гэж ангилах шаардлагатай.
39. **Олон ажил олгогчийн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийг зогсоон татан буулгах буюу олон ажил олгогчийн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрөөс уг байгууллага татгалзан гарахтай холбоотой өр төлбөрийг хэзээ хүлээн зөвшөөрөх ба хэрхэн хэмжихийг тодорхойлохдоо байгууллага нь УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийг дагаж мөрдөнө.**

**Ерөнхий хяналтанд буй байгууллагуудад эрсдлийг хуваах тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр**

40. Ерөнхий хяналтанд буй байгууллагуудад, тухайлбал хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй байгууллагуудад эрсдлийг хуваах тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр нь олон ажил олгогчийн хөтөлбөр биш юм.

41. Ийм хөтөлбөрт оролцож буй байгууллага нь уг хөтөлбөрт бүхэлдээ хэрэглэх төсөөллүүдэд үндэслэн тухайн хөтөлбөрийг бүхэлд нь энэхүү Стандартын дагуу хэмжсэн талаархи мэдээллийг олж авах хэрэгтэй. Бүхэлдээ энэхүү Стандартын дагуу хэмжигдсэн тийм хөтөлбөрийн хувьд түүний тогтоосон тэтгэмжийн цэвэр зардлыг тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх бие даасан байгууллагуудад хуваарилан нэхэмжлэх талаархи гэрээний тохиролцоо, заавал биелүүлэх хэлцэл эсвэл тогтсон бодлого хэрэв байгаа бол тухайн байгууллага нь ингэж хуваарилан нэхэмжилсэн, тогтоосон тэтгэмжийн цэвэр зардлыг өөрийн тусдаа буюу бие даасан санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Хэрэв ийм тохиролцоо, хэлцэл эсвэл бодлого байхгүй бол тухайн хөтөлбөрийн хувьд хууль ёсоор санхүүжүүлэгч-ажил олгогч болох уг байгууллагын тусдаа буюу бие даасан санхүүгийн тайланд тэрхүү тогтоосон тэтгэмжийн цэвэр зардлыг хүлээн зөвшөөрнө. Харин уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын бусад байгууллагууд нь тухайн тайлант үеийн хувьд өөрийн төлөх шимтгэлтэй тэнцүү дүнгээр зардлыг өөрсдийн тусдаа буюу бие даасан санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрнө.
42. Хяналт тавигч байгууллага болон хяналтанд буй нэг буюу хэд хэдэн байгууллагууд нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрт оролцох тохиолдол улсын секторт гардаг. 41-р параграфт заасанчлан, гэрээний тохиролцоо, заавал биелүүлэх хэлцэл эсвэл тогтсон бодлого байхаас бусад тохиолдолд уг хяналтанд буй байгууллага нь тогтоосон шимтгэлд үндэслэн тайлагнана, харин хяналт тавигч байгууллага нь тогтоосон тэтгэмжид үндэслэн өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тайлагнадаг. Хяналтанд буй байгууллага нь тогтоосон шимтгэлд үндэслэн тайлагнасан гэдгээ өөрийн тусдаа санхүүгийн тайландаа бас тодруулна. Тогтоосон шимтгэлд үндэслэн тайлагнадаг, хяналтанд буй байгууллага нь уг хяналт тавигч байгууллагын талаархи дэлгэрэнгүй мэдээллээр мөн хангах бөгөөд нягтлан бодох бүртгэл нь тогтоосон тэтгэмжид үндэслэсэн гэдгийг тухайн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд илэрхийлнэ. Хяналтанд буй байгууллага нь 151-р параграфтаар шаардсан тодруулгыг мөн бэлтгэнэ.
43. **Ийм хөтөлбөр дэх оролцоо нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх бие даасан байгууллага тус бүрийн хувьд холбоотой талуудын ажил гүйлгээ болно. Иймээс байгууллага нь 151-р параграфтаар шаардсан мэдээллийг өөрийн тусдаа буюу бие даасан санхүүгийн тайланд тодруулна.**

#### Улсын хөтөлбөр

44. **Байгууллага нь олон ажил олгогчийн хөтөлбөрийг бүртгэсэнтэй ижил арга замаар улсын хөтөлбөрийг тайлагнана (32 ба 39-р параграфыг үзнэ үү).**
45. Бүх байгууллагуудыг (эсвэл тухайлсан ангиллын, жишээлбэл, тодорхой нэг салбарын бүх байгууллагуудыг) хамруулах үүднээс улсын хөтөлбөрийг хуулиар үүсгэн байгуулдаг бөгөөд үндэсний, мужийн, орон нутгийн засаг захиргаа буюу бусад байгууллага (тухайлбал; энэ зорилгоор тусгайлан

байгуулсан бие даасан агентлаг) нь улсын хөтөлбөрийг эрхлэн ажиллуулдаг. Энэ Стандарт нь тухайн байгууллагын ажилтны зөвхөн тэтгэмжийг зохицуулдаг, харин уг тайлагнагч байгууллагын хяналтанд байдаггүй байгууллагуудын одоогийн болон хуучин ажилтнуудтай холбоотойгоор улсын хөтөлбөрийн дагуу үүсэх аливаа үүргийн тайлагналыг авч үзээгүй болно. Засгийн газар нь улсын хөтөлбөрийг хэрэгжүүлж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажилтнууд болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд тэтгэмж олгож болох боловч ийм хөтөлбөртэй холбоотойгоор үүссэн үүргийг энэ Стандартад авч үзэхгүй. Байгууллагын үүсгэн байгуулсан зарим хөтөлбөр нь хэрэв уг хөтөлбөрөөр олгохгүй бол улсын хөтөлбөрт хамруулах байсан тэтгэмжүүдийг орлох тийм албан журмын тэтгэмж, түүнчлэн сайн дурын нэмэлт тэтгэмжийн аль алиныг олгодог. Гэхдээ ийм хөтөлбөр нь улсын хөтөлбөр биш юм.

46. Улсын олон хөтөлбөрийг “шаардлагатай хэмжээгээр төлөх” зарчмаар санхүүжүүлдэг: энэ нь тухайн тайлант үед төлөх шаардлагатай тэтгэмжийг төлж барагдуулахад хангалттай байхаар хүлээгдэж буй тийм түвшнээр шимтгэлийг тогтоодог; тухайн тайлант үеийн туршид олж хуримтлагдсан ирээдүйн тэтгэмжийг ирээдүйн шимтгэлээс төлнө. Улсын хөтөлбөрт хамрагдсан байгууллагууд нь ийм хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөр эсвэл тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн аль нэг байдлаар тайлагнадаг. Нягтлан бодох бүртгэлийн арга хандлага нь тухайн байгууллага ирээдүйн тэтгэмжийг төлөх хуулийн эсвэл гэрээний бус үүрэгтэй эсэхээс хамаардаг. Байгууллагын цорын ганц үүрэг нь төлөх ёстой болсон шимтгэлээ төлж барагдуулах явдал бөгөөд ирээдүйн тэтгэмжийг төлөх үүрэггүй бол тус байгууллага нь уг улсын хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөр гэж тайлагнана.
47. Хяналтанд буй байгууллага нь улсын хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөр гэж ангилж болно. Гэвч хяналт тавигч байгууллагын хувьд уг улсын хөтөлбөр нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөртэй адил шинж чанартай гэсэн няцааж болох урьдчилсан нөхцөлтэй байдаг. Энэхүү урьдчилсан нөхцөл няцаагдсан тохиолдолд уг улсын хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөр гэж тайлагнана.

#### **Даатгуулсан тэтгэмж**

48. **Байгууллага нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрийг санхүүжүүлэхийн тулд даатгалын шимтгэл төлж болох юм. Байгууллага нь (уг хөтөлбөрийн хувьд шууд буюу шууд бусаар) дараах хуулийн эсвэл гэрээний бус үүрэгтэй байхаас бусад тохиолдолд тухайн байгууллага нь ийм хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөр гэж үзнэ:**
- (a) **Ажилтны тэтгэмжийг төлөх болсон үед шууд төлөх; эсвэл**
  - (б) **Тухайн тайлант үед болон өмнөх үеүдэд ажилтны үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой ажилтны ирээдүйн бүх тэтгэмжүүдийг даатгагч төлөөгүй бол цаашдын нэмэлт дүнг төлөх.**

**Хэрэв байгууллага нь ийм хуулийн эсвэл гэрээний бус үүрэгтэй бол тухайн байгууллага нь уг хөтөлбөрийг тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр гэж үзнэ.**

49. Даатгалын гэрээгээр даатгагдсан тэтгэмж нь ажилтны тэтгэмжийн хувьд тухайн байгууллагын хүлээх үүрэгтэй шууд буюу автоматаар харилцан холбоотой байх албагүй юм. Даатгалын гэрээг агуулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр нь бусад санхүүжүүлэлт бүхий хөтөлбөрүүдийн адилаар нягтлан бодох бүртгэл ба санхүүжилтийн хувьд мөн адил, онцлог ялгаатай байдаг.
50. Байгууллага нь хуулийн эсвэл гэрээний бус үүргийг хүлээх (шууд эсвэл уг хөтөлбөрөөр дамжуулан, ирээдүйн даатгалын шимтгэлийг тогтоох арга механизмын дагуу, тухайн даатгагчтай холбоотой талтай холбогдох харилцан холбоогоор дамжуулан шууд бусаар) даатгалын гэрээнд шимтгэл төлснөөр ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн үүргээ санхүүжүүлдэг тохиолдолд уг даатгалын шимтгэлийн төлбөр нь тогтоосон шимтгэлийн хөтөлбөртэй ижил дүнтэй байдаггүй. Иймээс байгууллага нь:
- (а) Шалгуур хангах даатгалын гэрээг хөтөлбөрийн хөрөнгө гэж тайлагнана (8-р параграфыг үзнэ үү); ба
  - (б) Даатгалын бусад гэрээг (хэрэв даатгалын гэрээ нь 118-р параграфт заасан шалгуурыг хангаж байвал) нөхөн төлбөрийн эрх гэж хүлээн зөвшөөрнө.
51. Даатгалын гэрээ нь хөтөлбөрийн тодорхой нэг оролцогчийн эсвэл хөтөлбөрийн оролцогчдын бүлгийн нэрээр байгаа бөгөөд тухайн байгууллага нь уг даатгалын гэрээний аливаа алдагдлыг нөхөн төлөх ямар нэг хуулийн эсвэл гэрээний бус үүрэг хүлээхгүй тохиолдолд уг байгууллага нь ажилтнуудад тэтгэмж төлөх үүрэггүй ба даатгагч нь тэтгэмжийг төлөх үүргийг дангаараа хүлээнэ. Ийм гэрээний дагуу даатгалын тогтмол хураамж төлөх нь мөн чанарын хувьд үүргийг барагдуулах хөрөнгө оруулалт биш, харин ажилтны тэтгэмжийн үүргийн барагдуулалт болох юм. Үүний үр дүнд байгууллага нь цаашид хөрөнгө эсвэл өр төлбөргүй болно. Иймээс байгууллага нь уг төлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөрт оруулсан шимтгэл гэж үзнэ.

### **Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж-Тогтоосон шимтгэлийн хөтөлбөр**

52. Тайлант үе тус бүрийн хувьд уг тайлагнагч байгууллагын хүлээх үүргийг тухайн тайлант үед шимтгэл байдлаар оруулах дүнгээр тодорхойлдог учраас тогтоосон шимтгэлийн хөтөлбөрийн тайлагнал нь энгийн, хялбар байдаг. Иймээс тухайн үүрэг буюу зардлыг хэмжихэд актуар төсөөлөл хийх шаардлагагүй бөгөөд ямар нэг актуар олз буюу гарз үүсэхгүй юм. Түүнчлэн, ажилтнууд нь холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор тухайн үүргийг бүрэн барагдуулахгүй байхаас бусад тохиолдолд тэдгээрийг дискаунтчлаагүй сууриар хэмжинэ.

**Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт**

53. Ажилтнууд нь тайлант үеийн туршид уг байгууллагад үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд тухайн байгууллага нь тогтоосон шимтгэлийн хөтөлбөрт уг үйлчилгээний хариу болгон төлөх шимтгэлийн өглөгийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:
- (а) Аль хэдийн төлсөн аливаа шимтгэлийг хассаны дараа, өр төлбөр (хуримтлагдсан зардал) байдлаар. Хэрэв аль хэдийн төлсөн шимтгэл нь тухайн тайлант үеийн эцсээс өмнөх үйлчилгээний хувьд төлөх ёстой шимтгэлийн дүнгээс илүү байвал уг урьдчилсан төлбөр нь тухайлбал, ирээдүйн төлбөрүүдийн бууралт эсвэл мөнгөн буцаан олголт болох тэр хэмжээгээр байгууллага нь илүү төлөлтийг хөрөнгө (урьдчилж төлсөн зардал) гэж хүлээн зөвшөөрнө.
  - (б) Өөр бусад Стандарт нь уг шимтгэлийг хөрөнгийн өртөгт оруулахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд (тухайлбал, УСНББОУС 12 ба УСНББОУС 17-г үзнэ үү) зардал байдлаар.
54. Тогтоосон шимтгэлийн хөтөлбөрт оруулах шимтгэл нь ажилтнууд холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор бүрэн төлөгдөхөөр хүлээгдээгүй байх тохиолдолд 85-р параграфт заасан дискаунтын түвшинг ашиглан уг шимтгэлийг дискаунтчилна.

**Тодруулга**

55. Байгууллага нь тогтоосон шимтгэлийн хөтөлбөрийн хувьд зардал гэж хүлээн зөвшөөрсөн дүнг тодруулна.
56. УСНББОУС 20-оор шаардсан тохиолдолд байгууллага нь эрх бүхий албан тушаалтнуудад зориулан тогтоосон шимтгэлийн хөтөлбөрт оруулсан шимтгэлийн талаархи мэдээллийг тодруулна.

**Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж-Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр**

57. Үүрэг ба зардлыг хэмжихийн тулд актуар төсөөлөл хийх шаардлагатай бөгөөд актуар олз, гарз үүсэх боломжтой учраас тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн тайлагнал нь нарийн цогц байдаг. Түүнчлэн, ажилтнууд нь холбогдох үйлчилгээгээ үзүүлснээс хойш олон жилийн дараа тэтгэмжийг төлж барагдуулж болох учраас уг үүргийг дискаунтчилсан сууриар хэмждэг.

**Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт**

58. Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр нь санхүүжигдээгүй<sup>4</sup> эсвэл тухайн тайлагнагч байгууллагаас хууль эрх зүйн хувьд тусгаар байх тийм байгууллага буюу санд уг байгууллагаас, зарим үед түүний ажилтнуудаас оруулсан шимтгэлээр бүрэн эсвэл хэсэгчлэн санхүүжигдсэн байж болох бөгөөд тэрхүү сангаас ажилтны тэтгэмжийг төлдөг. Төлөх хугацаа болсон уг санхүүжигдсэн тэтгэмжүүдийн төлөгдөх байдал нь зөвхөн тухайн сангийн санхүүгийн байдал ба хөрөнгө оруулалтын үр дүнгээс гадна сангийн хөрөнгийн аливаа дутагдлыг нөхөх байгууллагын чадвар, түүнчлэн бэлэн байдлаас хамаардаг. Ийм учраас тухайн байгууллага нь мөн чанартаа уг хөтөлбөртэй холбоотой актуар болон хөрөнгө оруулалтын эрсдлүүдийг хариуцдаг. Иймээс тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд хүлээн зөвшөөрсөн зардал нь тухайн тайлант үед төлөх шимтгэлийн дүнтэй заавал ижил байх албагүй юм.
59. Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийг байгууллага бүртгэж, тайлагнахад дараах алхамуудыг гүйцэтгэнэ:
- (a) Дутагдал буюу илүүдлийг тодорхойлох. Үүнд:
- (i) Тайлант үед болон өмнөх үеүдэд үзүүлсэн үйлчилгээнийхээ хариуд ажилтнуудын олж хуримтлуулсан тэтгэмжийн үр дүнд тухайн байгууллагаас гарах эцсийн зардлыг найдвартай тооцоолохын тулд актуар арга зүй буюу төсөвлөсөн нэгжийн кредит аргыг ашиглах (69-71-р параграфыг үзнэ үү). Энэ нь тайлант үед болон өмнөх үеүдэд хамаарах тэтгэмжийн дүн хэд болохыг тодорхойлох (72-76-р параграфыг үзнэ үү), тэтгэмжийн зардалд (77-100-р параграфыг үзнэ үү) нөлөөлөх хүн ам зүйн хувьсагчид (ажилтнуудын ажлаас гарах ба орох хөдөлгөөн, нас баралт гэх мэт) болон санхүүгийн хувьсагчдын (цалин ба эрүүл мэндийн зардлын ирээдүйн өсөлт гэх мэт) хувьд тооцоолол (актуар төсөөлөл) хийхийг байгууллагаас шаарддаг.
  - (ii) Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ ба одоогийн үйлчилгээний зардлыг тодорхойлохын тулд уг тэтгэмжийг дискаунтчлах (69-71, 85-88-р параграфыг үзнэ үү).
  - (iii) Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнээс хөтөлбөрийн аливаа хөрөнгийн бодит үнэ цэнийг (115-117-р параграфыг үзнэ үү) хасах.
- (б) Тогтоосон тэтгэмжийн цэвэр хөрөнгийг тухайн хөтөлбөрийн хөрөнгийн дээд хязгаарт багтаан хязгаарласны аливаа үр нөлөөний хувьд тохируулагдсан, дээрх (a)-д тодорхойлсон дутагдал буюу

<sup>4</sup> Unfunded буюу Санхүүжигдээгүй хөтөлбөр гэдэг нь уг байгууллага эсвэл түүний ажилтнуудаас урьдчилан шимтгэл төлж, ямар нэг хуримтлал буюу сан үүсгэхгүй боловч тэтгэвэр, тэтгэмжийг төлөх шаардлагатай болсон тухайн тайлант үеийн орлого, ашгаас төлөх тийм тэтгэвэр, тэтгэмжийн арга хэмжээг хэлдэг. Ред Ч.Д.

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

илүүдлийн дүнгээр тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дүнг тодорхойлох (66-р параграфыг үзнэ үү).

- (в) Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх дараах дүнгүүдийг тодорхойлох:
  - (i) Одоогийн үйлчилгээний зардал (72-76-р параграфыг үзнэ үү).
  - (ii) Аливаа өнгөрсөн үйлчилгээний зардал ба барагдуулалтаас үүссэн олз, гарз (101-114-р параграфыг үзнэ үү).
  - (iii) Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүү (125-128-р параграфыг үзнэ үү).
- (г) Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх, тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилтийн дүнг тодорхойлох, энэ нь дараах зүйлсээс бүрдэнэ:
  - (i) Актуар олз, гарз (130 ба 131-р параграфыг үзнэ үү);
  - (ii) Хөтөлбөрийн хөрөнгийн өгөөж, гэхдээ үүнд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүнд багтсан дүнг оруулахгүй (132-р параграфыг үзнэ үү); ба
  - (iii) Хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөнд гарсан аливаа өөрчлөлт (66-р параграфыг үзнэ үү), гэхдээ үүнд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүнд багтсан дүнг оруулахгүй.

Байгууллага нь тогтоосон тэтгэмжийн нэгээс олон хөтөлбөртэй тохиолдолд уг байгууллага нь материаллаг хөтөлбөр нэг бүрийн хувьд эдгээр горимуудыг тус тусад нь мөрдөнө.

- 60. **Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн, тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө) нь тухайн тайлант үеийн эцэст тодорхойлох дүнгээс материаллаг зөрүүтэй байлгахгүйн тулд байгууллага нь тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг хангалттай зохистойгоор тодорхойлох хэрэгтэй.**
- 61. Ажил эрхлэлтийн дараах бүх материаллаг тэтгэмжийн үүргийн хэмжилтийн хувьд байгууллага нь мэргэшсэн актуарч оролцуулахыг энэ Стандартаар сайшаан дэмждэг боловч ингэхийг заавал шаарддаггүй. Практик учир шалтгааны улмаас байгууллага нь тухайн тайлант үеийн эцэс болохоос өмнө уг үүргийн нарийвчилсан үнэлгээ хийхийг мэргэшсэн актуарчаас хүсэж болох юм. Гэхдээ тухайн тайлант үеийн эцэс хүртэлх аливаа материаллаг ажил гүйлгээ ба нөхцөл байдлын бусад өөрчлөлтийн (үүн дотроо зах зээлийн үнийн болон хүүний түвшний өөрчлөлт) хувьд тухайн үнэлгээний үр дүнг шинэчлэн баяжуулна.
- 62. Зарим тохиолдолд тооцоолол, дундаж дүн, хялбарчилсан тооцоолол нь энэ Стандартад жишээгээр үлгэрчлэн харуулсан, дэлгэрэнгүй тооцооллын боломжит ойролцоо дүнг илэрхийлж болох юм.



### Гэрээний бус үүргийн тайлагнал

63. **Байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн зөвхөн албан ёсны нөхцлийн дагуу хүлээх өөрийн хуулийн үүрэг төдийгүй тухайн байгууллагын албан бус практикаас үүссэн аливаа гэрээний бус үүргийг мөн тайлагнана. Албан бус практик нь тухайн байгууллага ажилтны тэтгэмжийг төлөх ба үүнээс өөр бодит сонголтгүй байх тийм гэрээний бус үүргийг үүсгэдэг. Байгууллагын уг албан бус практикын өөрчлөлт нь ажилтнуудтай тогтоосон түүний харилцаанд хүлээн зөвшөөрөх боломжгүй хохирол учруулахаар байх нь гэрээний бус үүргийн жишээ болно.**
64. Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн албан ёсны нөхцөл нь уг хөтөлбөрийн дагуу хүлээх өөрийн үүргийг дуусгавар болгох боломжийг байгууллагад олгож болох юм. Гэвч ажилтнуудыг ажиллуулсан хэвээр байгаа бол байгууллага нь хөтөлбөрийн дагуу хүлээх өөрийн үүргийг (төлбөрийг төлөхгүйгээр) дуусгавар болгоход ихэвчлэн амаргүй байдаг. Иймээс эсрэг нотолгоо байхгүй тохиолдолд тэтгэмж олгохоор одоо амлаж буй байгууллага нь тэрхүү тэтгэмжийг өөрийн ажилтнуудын ажиллах үлдсэн хугацааны туршид олгох тэр хэвээр байна гэж ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн тайлагналд авч үзнэ.

### Санхүүгийн байдлын тайлан

65. **Байгууллага нь тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг санхүүгийн байдлын тайландаа хүлээн зөвшөөрнө.**
66. **Байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд илүүдэлтэй байгаа тохиолдолд тогтоосон тэтгэмжийн цэвэр хөрөнгийг дараах хоёр дүнгийн аль багаар нь хэмжинэ:**
- (а) **Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн илүүдэл; ба**
  - (б) **85-р параграфт заасан дискаунтын түвшинг ашиглан тодорхойлсон хөтөлбөрийн хөрөнгийн дээд хязгаар.**
67. Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийг илүү дүнгээр санхүүжүүлсэн эсвэл актуар олз бий болсон тохиолдолд тогтоосон тэтгэмжийн цэвэр хөрөнгө үүсэж болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь тогтоосон тэтгэмжийн цэвэр хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Яагаад гэвэл:
- (а) Ирээдүйн үр өгөөж бий болгохын тулд уг илүүдлийг ашиглах боломжит байдал буюу нөөцийг байгууллага хянадаг;
  - (б) Тэрхүү хяналт нь өнгөрсөн үйл явдлуудын (байгууллагын төлсөн шимтгэл ба ажилтны үзүүлсэн үйлчилгээний) үр дүн байдаг;
  - (в) Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь тухайн байгууллагад шууд эсвэл хөрөнгө дутагдалтай байгаа өөр хөтөлбөрт шууд бусаар олгох мөнгөн буцаалтын хэлбэрээр эсвэл ирээдүйн шимтгэлийн бууралтын

хэлбэрээр уг байгууллагад орох боломжтой байдаг. Хөрөнгийн дээд хязгаар нь тэдгээр ирээдүйн үр өгөөжийн өнөөгийн үнэ цэнэ юм.

**Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт-Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ ба одоогийн үйлчилгээний зардал**

68. Сүүлийн жилийн цалин, ажилтнуудын эргэц хөдөлгөөн, нас баралт, ажилтны шимтгэл, эрүүл мэндийн зардлын өөрчлөлт хандлага гэх мэт олон хувьсагчид нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн эцсийн зардалд нөлөө үзүүлж болох юм. Хөтөлбөрийн эцсийн зардал нь тодорхой бус бөгөөд ийм тодорхой бус байдал нь удаан хугацааны туршид үргэлжлэх магадлалтай байдаг. Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ ба холбогдох одоогийн үйлчилгээний зардлыг хэмжихийн тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай:
- (а) Актуар үнэлгээний арга хэрэглэх (69-71-р параграфыг үзнэ үү);
  - (б) Үйлчилгээ үзүүлсэн тайлант үеүдэд тэтгэмжийг хамааруулан хуваарилах (72-76-р параграфыг үзнэ үү); ба
  - (в) Актуар төсөөлөл хийх (77-100-р параграфыг үзнэ үү).

*Актуар үнэлгээний арга*

69. **Байгууллага нь өөрийн тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ ба холбогдох одоогийн үйлчилгээний зардлыг, мөн түүнчлэн боломжтой бол өнгөрсөн үйлчилгээний зардлыг тодорхойлохын тулд төсөвлөсөн нэгжийн кредит аргыг ашиглана.**
70. Төсөвлөсөн нэгжийн кредит аргын (зарим үед, үйлчилгээнд хувь тэнцүүлэн тооцсон, хуримтлагдсан тэтгэмжийн арга эсвэл тэтгэмж/үйлчилгээний жилүүдийн арга гэж нэрлэдэг) дагуу, үйлчилгээний тайлант үе (ажилласан жил) бүр нь тэтгэмж авах эрхийн нэмэлт нэгжийг үүсгэнэ гэж үздэг (72-76-р параграфыг үзнэ үү) бөгөөд эцсийн үүргийг хуримтлуулан тооцохын тулд нэгж бүрийг тусад нь хэмждэг (77-100-р параграфыг үзнэ үү).
71. Хэдийгээр үүргийн зарим хэсгийг тухайн тайлант үеийн эцсээс хойш арван хоёр сарын дотор барагдуулахаар хүлээгдэж байлаа ч гэсэн байгууллага нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн үүргийг бүхэлд нь дискаунтчилна.

*Үйлчилгээ үзүүлсэн тайлант үеүдэд тэтгэмжийг хамааруулан хуваарилах*

72. **Өөрийн тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ ба холбогдох одоогийн үйлчилгээний зардлыг, мөн түүнчлэн боломжтой бол өнгөрсөн үйлчилгээний зардлыг тодорхойлохдоо байгууллага нь уг хөтөлбөрийн тэтгэмжийн томъёоллын дагуу тэтгэмжийг үйлчилгээ үзүүлсэн тайлант үеүдэд хамааруулан хуваарилна. Гэвч ажилтнуудын сүүлийн жилүүд дэх үйлчилгээ нь эхний жилүүд дэх үйлчилгээнээс материаллагаар өндөр тэтгэмж бий болгохоор байвал байгууллага нь тэтгэмжийг дараах хугацааны хооронд шулуун шугамын сууриар хамааруулан хуваарилна:**

- (а) **Ажилтны үзүүлсэн үйлчилгээ нь уг хөтөлбөрийн дагуу тэтгэмж тооцоход анх хүргэж буй өдрөөс (тэтгэмж нь цаашид үзүүлэх үйлчилгээнээс нөхцөлт хамааралтай эсэхээс үл хамааран)**
- (б) **Ажилтны цаашид үзүүлэх үйлчилгээ нь цалингийн ирээдүйн өсөлтөөс өөр бусад, уг хөтөлбөрийн дагуу олгогдох материаллаг дүн бүхий цаашдын тэтгэмжийг үүсгэхгүй болох өдөр хүртэл.**
73. Төсөвлөсөн нэгжийн кредит арга нь тэтгэмжийг тухайн тайлант үед (одоогийн үйлчилгээний зардлыг тодорхойлохын тулд), түүнчлэн тухайн тайлант үе болон өмнөх үеүдэд (тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд) хамааруулан хуваарилахыг аж ахуйн нэгжээс шаарддаг. Байгууллага нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийг олгох үүрэг үүссэн тайлант үеүдэд тэтгэмжийг хамааруулан хуваарилна. Ирээдүйн тайлант үеүдэд байгууллагын төлөхөөр хүлээгдэж буй ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хариуд ажилтан нь үйлчилгээ үзүүлснээр уг үүрэг үүсдэг. Актуар арга зүй нь өр төлбөр хүлээн зөвшөөрөх үндэслэлийг гаргахын тулд уг үүргийг хангалттай найдвартайгаар хэмжих боломжийг байгууллагад олгодог.
74. Тэтгэмж нь ирээдүйн ажил эрхлэлтээс нөхцөлт хамааралтай (өөрөөр хэлбэл, энэ нь баталгаагүй) байлаа ч гэсэн ажилтны үйлчилгээ нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу үүрэг үүсэхэд хүргэдэг. Тэтгэмж авах эрхтэй болохоос өмнө ажилтны үзүүлэх шаардлагатай ирээдүйн үйлчилгээний хэмжээ нь дараа дараагийн тайлант үе бүрийн эцэст багасах тул тийм баталгаатай болохоос өмнө уг ажилтны үзүүлсэн үйлчилгээ нь гэрээний бус үүргийг үүсгэнэ. Өөрийн тогтоосон тэтгэмжийн үүргийг хэмжихдээ байгууллага нь ийм баталгаатай болох аль нэг шаардлагыг зарим ажилтнууд хангахгүй байж болох магадлалыг харгалзан үздэг. Үүнтэй адилаар, ажил эрхлэлтийн дараах зарим тэтгэмж тухайлбал, ажил эрхлэлтийн дараах эрүүл мэндийн тэтгэмж нь тусгайлан заасан тодорхой нэг үйл явдал тухайн ажилтныг ажиллахаа больсноос хойшхи хугацаанд гарч тохиолдсон зөвхөн тэр үед төлөгдөх боловч тийм тусгай үйл явдал гарч тохиолдох үед тэтгэмж авах эрхийг бүрдүүлэх үйлчилгээг уг ажилтан үзүүлснээр үүрэг үүсдэг. Ийм тусгайлан заасан үйл явдал гарч тохиолдох магадлал нь үүргийн хэмжилтэнд нөлөөлдөг боловч уг үүрэг оршин байгаа эсэхийг тодорхойлохгүй.
75. Ажилтны цаашид үзүүлэх үйлчилгээ нь материаллаг дүн бүхий цаашдын тэтгэмжийг үүсгэхгүй болох өдөр хүртэл уг үүрэг нэмэгдэнэ. Иймээс уг өдрөөр эсвэл түүнээс өмнө дуусгавар болох тайлант үеүдийн хувьд бүх тэтгэмжийг хамааруулан хуваарилна. Тухайн хөтөлбөрийн тэтгэмжийн томъёоны дагуу тэтгэмжийг нягтлан бодох бүртгэлийн тусдаа тайлант үеүдэд хамааруулан хуваарилна. Гэвч ажилтны сүүлийн жилүүд дэх үйлчилгээ нь эхний жилүүд дэх үйлчилгээнээс материаллагаар өндөр түвшний тэтгэмж бий болгохоор байвал ажилтны цаашид үзүүлэх үйлчилгээ нь материаллаг дүн бүхий цаашдын тэтгэмжийг үүсгэхгүй болох тийм өдөр хүртэл байгууллага нь тэтгэмжийг шулуун шугамын сууриар хуваарилна. Нийт хугацааны туршид ажилтны үзүүлсэн үйлчилгээ нь

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

эцэстээ ийм өндөр түвшнээр тэтгэмжийг тооцоход хүргэх тул ингэж хуваарилалт хийдэг.

76. Тэтгэмжийн дүн нь үйлчилгээ үзүүлсэн жил бүрийн хувьд сүүлийн жилийн цалингийн тогтмол хувиар илэрхийлэгдэх тохиолдолд ирээдүйн цалингийн өсөлт нь уг тайлант үеийн эцсээс өмнөх үйлчилгээний хувьд үүссэн үүргийг барагдуулахад шаардлагатай дүнд нөлөөлөх боловч нэмэлт үүрэг үүсгэхгүй. Иймээс:
- (a) Дээрх 72(б) параграфт дурдсан зорилгын хувьд, хэдийгээр тэтгэмжийн дүн нь сүүлийн жилийн цалингаас хамаарах боловч цалингийн өсөлт нь нэмэлт тэтгэмжийг бий болгохгүй; ба
  - (б) Тайлант үе бүрд хамааруулан хуваарилах тэтгэмжийн дүн нь уг тэтгэмжийн хамаарах цалингийн тогтмол хувиар илэрхийлэгдэнэ.

### *Актуар төсөөлөл*

77. Актуар төсөөлөл нь аль нэг тал руу хэлбийгээгүй бөгөөд харилцан хүлээн зөвшөөрөхүйц байвал зохино.
78. Актуар төсөөлөл нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийг олгох эцсийн зардлыг тодорхойлох хувьсагчдын талаархи уг байгууллагын хамгийн сайн тооцоолол байдаг. Актуар төсөөлөл нь дараах зүйлсээс бүрддэг:
- (a) Тэтгэмж авах шаардлагыг хангасан одоогийн ба хуучин ажилтнуудын (болон тэдний асран хамгаалуулагчдын) ирээдүйн шинж байдлын талаархи хүн ам зүйн төсөөллүүд. Хүн ам зүйн төсөөллүүд нь доорх гэх мэт асуудалтай холбоотой байдаг:
    - (i) Нас баралт (83 ба 84-р параграфыг үзнэ үү);
    - (ii) Ажилтны эргэц хөдөлгөөн, хөдөлмөрийн чадвар алдалт, тэтгэвэрт эрт гаралтын хувь хэмжээ;
    - (iii) Тэтгэмж авах шаардлагыг хангасан бөгөөд асран хамгаалуулагч бүхий уг хөтөлбөрийн гишүүдийн хувийн жин;
    - (iv) Хөтөлбөрийн нөхцлийн дагуу бэлэн боломжтой байх төлбөрийн сонголтын хэлбэр нэг бүрийг сонгох уг хөтөлбөрийн гишүүдийн хувийн жин;
    - (v) Эрүүл мэндийн хөтөлбөрийн дагуу нэхэмжлэл гаргах хувь хэмжээ;
  - (б) Доорх гэх мэт зүйлстэй холбоотой санхүүгийн төсөөллүүд:
    - (i) Дискаунтын түвшин (85-88-р параграфыг үзнэ үү);
    - (ii) Тэтгэмжийн түвшин, үүнд ажилтнууд болон тэдний ирээдүйн цалингаар нөхөгдөх тэтгэмжийн аливаа зардал хамаарахгүй (89-97-р параграфыг үзнэ үү);

- (iii) Эрүүл мэндийн тэтгэмжийн хувьд ирээдүйн эрүүл мэндийн зардал, үүнд нэхэмжлэлийг хариуцан шийдэх зардал хамаарна (өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийг боловсруулах ба шийдвэрлэхэд гарах зардлууд, үүн дотроо хууль эрх зүйн болон тохируулагчийн хөлс) (98-100-р параграфыг үзнэ үү); ба
  - (iv) Тайлант үеийн эцсийн өдрөөс өмнөх үйлчилгээтэй холбоотой шимтгэл болон тухайн үйлчилгээнээс бий болох тэтгэмжийн хувьд уг хөтөлбөрийн хариуцах татварын өглөг.
79. Актуар төсөөлөл нь оновчгүй эсвэл хэт болгоомжилж, бууруулан тооцсон биш бол түүнийг аль нэг тал руу хэлбийгээгүй гэж үзнэ.
80. Актуар төсөөлөл нь инфляци, цалингийн өсөлтийн түвшин, дискаунтын түвшин гэх мэт хүчин зүйлсийн хоорондох эдийн засгийн харилцан хамаарлыг тусгасан бол түүнийг харилцан хүлээн зөвшөөрөхүйц гэж үзнэ. Тухайлбал, ирээдүйн аливаа нэг тайлант үе дэх тухайн тодорхой инфляцийн түвшнээс хамаарах бүх төсөөллүүдийн (хүүний түвшний төсөөлөл, цалингийн болон тэтгэмжийн өсөлтийн талаархи төсөөлөл гэх мэт) хувьд уг тайлант үеийн тэрхүү инфляцийн түвшинг харгалзан үзнэ.
81. Бодит дүнгээр илэрхийлсэн (инфляциар тохируулсан) тооцоолол нь илүү найдвартай, тухайлбал; хэт инфляцитай эдийн засгийн нөхцөлд (УСНББОУС 10, *Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал*-ыг үзнэ үү) эсвэл уг тэтгэмжийг индексжүүлдэг бөгөөд нэг ижил төрлийн валют, нөхцөл бүхий индексжүүлсэн бондын өргөн зах зээлтэй байхаас бусад тохиолдолд байгууллага нь дискаунтын түвшин болон санхүүгийн бусад төсөөллүүдийг нэрлэсэн (тогтоосон) дүнгээр тодорхойлно.
82. **Үүргийг барагдуулах тайлант үеийн талаархи санхүүгийн төсөөллүүд нь тухайн тайлант үеийн эцсээрх зах зээлийн хүлээлтэнд үндэслэнэ.**

*Актуар төсөөлөл: нас баралт*

83. **Байгууллага нь уг хөтөлбөрт хамрагдсан гишүүдийн ажил эрхлэлтийн явцад болон түүнээс хойшхи нас баралтын талаархи өөрийн хамгийн сайн тооцоололд үндэслэн нас баралтын талаархи төсөөллийг хийдэг.**
84. Тэтгэмжийн эцсийн зардлыг тооцоолохын тулд байгууллага нь нас баралтын хувьд гарахаар хүлээгдэж буй өөрчлөлтийг харгалзан үздэг. Жишээлбэл; нас баралтын стандарт хүснэгтийг түүний сайжруулсан тооцооллоор өөрчлөн баяжуулах.

*Актуар төсөөлөл: Дискаунтын түвшин*

85. **Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн үүргийг (санхүүжигдсэн ба санхүүжигдээгүй аль алины хувьд) дискаунтчлахад ашиглах хувь хэмжээ буюу түвшин нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусгадаг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусгахын тулд сонгосон**

**санхүүгийн хэрэглүүрийн валют ба нөхцөл нь уг ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн үүргийн валют ба тооцоолсон нөхцөлтэй нийцсэн байвал зохино.**

86. Материаллаг нөлөө бүхий актуар нэг төсөөлөл нь дискаунтын түвшин юм. Дискаунтын түвшин нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусган илэрхийлэх боловч актуар буюу хөрөнгө оруулалтын эрсдлийг илэрхийлдэггүй. Түүнчлэн, дискаунтын түвшин нь байгууллагын зээлдүүлэгчдийн хүлээх, уг байгууллагын тусгайлсан зээлийн эрсдлийг ч илэрхийлэхгүй, мөн тухайн ирээдүйн бодит байдал нь актуар төсөөллөөс өөр байж болох эрсдлийг ч тусган илэрхийлдэггүй.
87. Дискаунтын түвшин нь тэтгэмжийн төлбөрүүдийн тооцоолсон хугацааг тусгадаг. Практикт байгууллага нь тэтгэмжийн төлбөрүүдийн тооцоолсон хугацаа ба дүн, уг тэтгэмжүүдийг төлөх валютыг тусган илэрхийлсэн жинэлсэн дундаж дискаунтын нэг түвшинг ашигласнаар үүнийг ихэвчлэн гүйцэтгэдэг.
88. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусган илэрхийлэх дискаунтын түвшинг тухайн тайлант үеийн эцэс дэх засгийн газрын бонд, корпорацийн өндөр чанартай бонд буюу бусад санхүүгийн хэрэглүүрийн зах зээлийн өгөөжийг лавлагаа болгосноор хамгийн сайнаар ойролцоогоор тооцоолж чадах эсэхийг уг байгууллага нь шүүн тунгаана. Зарим улс орны хувьд тухайн тайлант үеийн эцэс дэх засгийн газрын бондын зах зээлийн өгөөж нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн талаархи хамгийн сайн ойролцоо тооцооллоор хангадаг. Гэвч ийм тооцооллоор хангадаггүй нөхцөл бүхий улс орнууд байж болох юм. Жишээлбэл; засгийн газрын бондын өргөн зах зээлгүй, эсвэл засгийн газрын бондын тухайн тайлант үеийн эцэс дэх зах зээлийн өгөөж нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусган илэрхийлдэггүй улс орнууд байж болно. Энэ тохиолдолд тайлагнагч байгууллага нь корпорацийн өндөр чанартай бондын зах зээлийн өгөөжийг лавлагаа болгох гэх мэт өөр бусад арга ашигласнаар дискаунтын түвшинг тодорхойлдог. Бүх тэтгэмжийн төлбөрүүдийн тооцоолсон дуусах хугацаатай тохирон уялдах хангалттай урт, дуусгавар болох хугацаа бүхий засгийн газрын бондын буюу корпорацийн өндөр чанартай бондын өргөн зах зээл байхгүй тийм нөхцөл байдал бас үүсэж болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь арай богино хугацаатай төлбөрүүдийг дискаунтчлахын тулд тохирох нөхцөл бүхий одоогийн зах зээлийн түвшнүүдийг ашиглах ба өгөөжийн муруйд үндэслэн одоогийн зах зээлийн түвшнүүдэд экстраполяцийн хувиргалт<sup>5</sup> хийснээр илүү урт дуусгавар болох хугацааны хувьд хэрэглэх дискаунтын түвшинг тооцоолдог. Тогтоосон тэтгэмжийн үүргийн нийт өнөөгийн үнэ цэнэ нь бэлэн боломжтой байгаа корпорацийн буюу засгийн газрын бондын эцсийн дуусгавар болох хугацаанаас хойш

<sup>5</sup> Extrapolating-Экстраполяци гэдэг нь одоогийн хандлага цааш үргэлжилнэ гэж төсөөлснөөр эсвэл өмнөх туршлагад үндэслэснээр тодорхой бус, үл мэдэгдэх нөхцөл байдалд арга дүгнэлтийг хэрэглэж, тооцоолол хийхийг хэлдэг. Тухайлбал; математик, эдийн засгийн тооцоололд төсөөтэй гурвалжны шинжийг ашигласнаар үл мэдэгдэх үзүүлэлтийг тооцоолж олдог. Ред Ч.Д.

төлөгдөх тэтгэмжийн тэр хэсэгт хэрэглэх дискаунтын түвшнээс тухайлан хамаарах тийм мэдрэмжтэй байх магадлал багатай юм.

*Актуар төсөөлөл-Цалин, тэтгэмж, эрүүл мэндийн зардал*

89. **Байгууллага нь өөрийн тогтоосон тэтгэмжийн үүргийг дараах зүйлийг харгалзан үзсэн сууриар хэмжинэ:**
- (a) Уг тайлант үеийн эцсээр хөтөлбөрийн нөхцөлд тусгасан (буюу тэдгээр нөхцөлд үл хамаарах аливаа гэрээний бус үүргээс үүсэх) тэтгэмжүүд;
  - (б) Тэтгэмжийн өглөгт нөлөөлөх, ирээдүйн цалингийн аливаа тооцоолсон өсөлт;
  - (в) Ирээдүйн тэтгэмжийн зардлын хувьд тухайн ажил олгогчийн хариуцах хувь хэмжээний талаар тогтоосон аливаа хязгаарлалтын үр нөлөө;
  - (г) Эдгээр тэтгэмжүүдийн улмаас уг байгууллагад учрах эцсийн зардлыг бууруулах бөгөөд ажилтнууд эсвэл гуравдагч талаас оруулах шимтгэл;
  - (д) Зөвхөн дараах хоёр тохиолдлын аль нэгний үр дүнд, тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу төлөх тэтгэмжийн өглөгт нөлөөлдөг улсын аливаа тэтгэмжийн түвшний ирээдүйн тооцоолсон өөрчлөлт:
    - (i) Тэдгээр өөрчлөлтүүд нь уг тайлант үеийн эцсээс өмнө хүчин төгөлдөр болсон; эсвэл
    - (ii) Улсын эдгээр тэтгэмжүүд нь урьдчилан таамаглаж болох тодорхой зарим арга маягаар, тухайлбал, үнийн ерөнхий түвшин буюу цалингийн ерөнхий түвшний ирээдүйн өөрчлөлтүүдтэй уялдаатайгаар өөрчлөгдөнө гэдгийг түүхэн тоон мэдээ эсвэл бусад найдвартай нотолгоо илэрхийлэн харуулж байгаа.
90. Актуар төсөөлөл нь уг тайлант үеийн эцсээр хөтөлбөрийн нөхцөлд тусгасан (буюу тэдгээр нөхцөлд үл хамаарах аливаа гэрээний бус үүргээс үүсэх) тэтгэмжийн ирээдүйн өөрчлөлтүүдийг тусгадаг. Тухайлбал; дараах нөхцөлд ийм тохиолдол үүсдэг:
- (a) Байгууллага нь жишээлбэл; инфляцийн үр нөлөөг бууруулахын тулд тэтгэмжийг нэмэгдүүлдэг түүхэн туршлагатай бөгөөд энэхүү практик нь ирээдүйд өөрчлөгдөх ямар нэг шинж тэмдэг байхгүй;
  - (б) Байгууллага нь хөтөлбөрийн аливаа илүүдлийг тухайн хөтөлбөрт оролцогчдын тэтгэмжинд зориулан ашиглах үүргийг уг хөтөлбөрийн албан ёсны нөхцлөөр (буюу тэдгээр нөхцөлд үл хамаарах аливаа гэрээний бус үүргээр) эсвэл хуулиар хүлээсэн байх (110(в) параграфыг үзнэ үү);

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

- (в) Тэтгэмж нь гүйцэтгэлийн зорилтот хэмжээ буюу бусад шалгуураас хамааран өөрчлөгддөг байх. Жишээлбэл; хэрэв хөтөлбөрийн хөрөнгө хүрэлцэхгүй бол тэтгэмжийг багасгаж төлөх буюу ажилтнуудаас нэмэлт шимтгэл авахаар уг хөтөлбөрийн нөхцөлд заасан байж болох юм. Үүргийн хэмжилт нь гүйцэтгэлийн зорилтот хэмжээ буюу бусад шалгуурын үр нөлөөний талаархи хамгийн сайн тооцооллыг тусгасан байдаг.
91. Актуар төсөөлөл нь тухайн тайлант үеийн эцсээр уг хөтөлбөрийн албан ёсны нөхцөлд (эсвэл гэрээний бус үүрэгт) заагаагүй ирээдүйн тэтгэмжийн өөрчлөлтүүдийг тусган илэрхийлдэггүй. Ийм өөрчлөлтүүдийг дараах байдлаар тусгана:
- (а) Тухайн өөрчлөлтөөс өмнөх үйлчилгээнд хамаарах тэтгэмжийг өөрчилсөн тэр хэмжээгээр өнгөрсөн үйлчилгээний зардалд;
- (б) Тухайн өөрчлөлтийн дараах үйлчилгээнд хамаарах тэтгэмжийг өөрчилсөн тэр хэмжээгээр уг өөрчлөлтийн дараах тайлант үеүдийн одоогийн үйлчилгээний зардалд.
92. Ирээдүйн цалингийн өсөлтийн тооцоололд инфляци, ажилласан жил, албан тушаалын дэвшилт, түүнчлэн хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, нийлүүлэлт гэх мэт бусад холбогдох хүчин зүйлсийг харгалздаг.
93. Тогтоосон тэтгэмжийн зарим хөтөлбөр нь байгууллагын төлөх шаардлагатай шимтгэлийн дүнг хязгаарласан байдаг. Төлөх шимтгэлийн энэхүү хязгаарлалтын үр нөлөөг тэтгэмжийн эцсийн зардлын тооцоололд харгалзан үздэг. Шимтгэлийн хязгаарлалтын үр нөлөөг дараах хугацааны аль богино байх хугацааны туршид тодорхойлдог:
- (а) Байгууллагын оршин тогтнох тооцоолсон хугацаа;
- (б) Хөтөлбөрийн оршин тогтнох тооцоолсон хугацаа.
94. Тогтоосон тэтгэмжийн зарим хөтөлбөр нь хөтөлбөрийн зардалд зориулан шимтгэл төлөхийг ажилтнууд буюу гуравдагч талаас шаарддаг. Ажилтнуудын оруулах шимтгэл нь тухайн байгууллагын хувьд гарах тэтгэмжийн зардлыг бууруулдаг. Гуравдагч талын шимтгэл нь байгууллагын хувьд гарах тэтгэмжийн зардлыг бууруулах эсвэл 118-р параграфт заасан, нөхөн төлбөрийн эрх болох эсэхийг уг байгууллага нь харгалзан үзнэ. Ажилтнууд болон гуравдагч талаас оруулах шимтгэлийг тухайн хөтөлбөрийн албан ёсны нөхцөлд заасан (буюу тэдгээр нөхцөлд үл хамаарах гэрээний бус үүргээс үүссэн), эсвэл энэ нь сайн дурын шинжтэй байдаг. Ажилтнууд эсвэл гуравдагч талаас оруулах сайн дурын шимтгэл нь уг хөтөлбөрт төлөгдсөн дүнгээр үйлчилгээний зардлыг бууруулдаг.
95. Хөтөлбөрийн албан ёсны нөхцөлд заасан, ажилтнууд эсвэл гуравдагч талаас оруулах шимтгэл нь үйлчилгээний зардлыг бууруулна (хэрэв эдгээр нь үйлчилгээтэй холбоотой бол) эсвэл тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилтэнд нөлөөлнө (хэрэв эдгээр нь үйлчилгээтэй холбоогүй бол). Хөтөлбөрийн хөрөнгийн гарз эсвэл актуар



гарзын улмаас үүссэн дутагдлыг бууруулахын тулд шимтгэл төлөхийг шаардах нь үйлчилгээтэй холбоогүй шимтгэлийн жишээ юм. Хэрэв ажилтнууд эсвэл гуравдагч талаас оруулах шимтгэл нь үйлчилгээтэй холбоотой бол тэдгээр шимтгэлийн дүнгээр үйлчилгээний зардлыг дараах байдлаар бууруулна:

- (а) Хэрэв шимтгэлийн дүн нь үйлчилгээ үзүүлсэн жилийн тооноос хамааралтай бол байгууллага нь нийт тэтгэмжийн хувьд 72-р параграфтаар шаардсантай ижил шинж чанар бүхий аргыг (өөрөөр хэлбэл, хөтөлбөрийн шимтгэлийн томъёог эсвэл шулуун шугамын суурийг) ашигласнаар шимтгэлийг уг үйлчилгээ үзүүлсэн тайлант үеүдэд хамааруулан хуваарилна;
- (б) Хэрэв шимтгэлийн дүн нь үйлчилгээ үзүүлсэн жилийн тооноос хамааралгүй бол холбогдох үйлчилгээг үзүүлсэн тайлант үеийн үйлчилгээний зардлын бууралт байдлаар тэрхүү шимтгэлүүдийг хүлээн зөвшөөрөхийг байгууллагад зөвшөөрдөг. Үйлчилгээ үзүүлсэн жилийн тооноос хамааралгүй шимтгэлийн жишээнд; ажилтны цалингаас тогтмол хувиар, үйлчилгээ үзүүлэх нийт хугацааны туршид тогтмол дүнгээр эсвэл ажилтны наснаас хамааран тооцох шимтгэлүүд хамаарна.

Мөрдөх холбогдох заавар удирдамжийг МЗУ13-р параграфт харуулсан.

96. Ажилтнууд буюу гуравдагч талаас оруулсан бөгөөд 95(а) параграфын дагуу үйлчилгээ үзүүлсэн тайлант үеүдэд хамааруулан хуваарилдаг шимтгэлүүдийн хувьд тэдгээрийн өөрчлөлтүүдийг дараах байдлаар тусгана:
- (а) Одоогийн болон өнгөрсөн үйлчилгээний зардалд (хэрэв тэдгээр өөрчлөлтийг уг хөтөлбөрийн албан ёсны нөхцөлд тусгадаггүй бөгөөд гэрээний бус үүргээс үүсээгүй бол); эсвэл
  - (б) Аaktuар олз, гарзад (хэрэв тэдгээр өөрчлөлтийг уг хөтөлбөрийн албан ёсны нөхцөлд тусгадаг эсвэл гэрээний бус үүргээс бий болдог бол).
97. Ажил эрхлэлтийн дараах зарим тэтгэмж нь тэтгэвэрт гарах үеийн улсын тэтгэмжийн түвшин эсвэл улсын эрүүл мэндийн халамж үйлчилгээний түвшин гэх мэт хувьсагчидтай холбоотой байдаг. Ийм тэтгэмжийн хэмжилт нь түүхэн мэдээ ба бусад найдвартай нотолгоонд үндэслэсэн, тэдгээр хувьсагчдын хамгийн сайн тооцооллыг тусган илэрхийлдэг.
98. **Эрүүл мэндийн зардлын талаархи төсөөлөл нь инфляци болон эрүүл мэндийн зардлын тусгай өөрчлөлтийн аль алины үр дүнд эрүүл мэндийн үйлчилгээний зардалд гарах ирээдүйн тооцоолсон өөрчлөлтийг харгалзсан байна.**
99. Ажил эрхлэлтийн дараах эрүүл мэндийн тэтгэмжийн зардлын хэмжилт нь ирээдүйн нэхэмжлэлийн түвшин, давтамж ба тэдгээр нэхэмжлэлийг барагдуулах зардлын талаар төсөөлөл хийхийг шаарддаг. Байгууллага нь өөрийн туршлагын талаархи түүхэн мэдээнд үндэслэж, шаардлагатай

тохиолдолд бусад байгууллага, даатгалын компани, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч буюу бусад эх сурвалжаас авсан түүхэн мэдээг лавлагаа болгосноор ирээдүйн эрүүл мэндийн зардлыг тооцоолдог. Ирээдүйн эрүүл мэндийн зардлын тооцоололд технологийн дэвшлийн үр нөлөө, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ашиглалт буюу нийлүүлэлтийн хэв маягийн өөрчлөлт, хөтөлбөрт оролцогчдын эрүүл мэндийн байдлын өөрчлөлтийг харгалзан үздэг.

100. Нэхэмжлэлийн түвшин ба давтамж нь ажилтнууд (болон тэдний асран хамгаалуулагчид)-ын нас, эрүүл мэндийн байдал, хүйсээс ихээхэн хамаардаг бөгөөд газарзүйн байршил гэх мэт бусад хүчин зүйлсээс хамаардаг байж болох юм. Иймээс хүн ам зүйн бүтэц нь тухайн мэдээний хувьд суурь болгон ашигласан хүн ам зүйн бүтцээс өөр байх тэр хэмжээгээр уг түүхэн мэдээг тохируулдаг. Тухайн түүхэн хандлага нь цаашид ингэж үргэлжлэхгүй гэсэн найдвартай нотолгоо байгаа тохиолдолд үүнийг мөн тохируулна.

### **Өнгөрсөн үйлчилгээний зардал ба барагдуулалтаас үүссэн олз, гарз**

101. **Өнгөрсөн үйлчилгээний зардал эсвэл барагдуулалтаас үүссэн олз, гарзыг тодорхойлохын өмнө байгууллага нь хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалтаас өмнөх, тухайн хөтөлбөрийн дагуу санал болгож буй тэтгэмжүүдийг тусган илэрхийлэх одоогийн актуар төсөөллүүдийг (үүн дотроо, одоогийн зах зээлийн хүүний түвшин ба одоогийн зах зээлийн бусад үнэ) болон хөтөлбөрийн хөрөнгийн одоогийн бодит үнэ цэнийг ашигласнаар уг тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг дахин хэмжинэ.**
102. Хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлтөөс үүссэн өнгөрсөн үйлчилгээний зардал, цомхотголоос үүссэн өнгөрсөн үйлчилгээний зардал, барагдуулалтаас үүссэн олз, гарзын ажил гүйлгээнүүд хэрэв хамтдаа гарч тохиолдсон бол байгууллага нь тэдгээрийг өөр хооронд нь ялган зааглах шаардлагагүй юм. Зарим тохиолдолд, барагдуулалт хийхээс өмнө хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулдаг, тухайлбал, байгууллага нь эхлээд хөтөлбөрийн дагуу олгох тэтгэмжийг өөрчилж, үүний дараа уг өөрчлөгдсөн тэтгэмжийг барагдуулдаг. Энэ тохиолдолд байгууллага нь өнгөрсөн үйлчилгээний зардлыг тухайн барагдуулалтын аливаа олз, гарзаас өмнө хүлээн зөвшөөрнө.
103. Хэрэв тухайн үүргийг барагдуулж, уг хөтөлбөр цаашид оршин байхаа болих үр дүнтэйгээр хөтөлбөрийг дуусгавар болгож байгаа бол барагдуулалт нь хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт ба цомхотголтой хамт хийгдэх юм. Гэвч мөн чанарын хувьд ижил тэтгэмжийг санал болгох шинэ хөтөлбөрөөр уг хөтөлбөрийг орлуулж байвал тэрхүү хөтөлбөрийн дуусгавар болголт нь барагдуулалт болохгүй юм.

*Өнгөрсөн үйлчилгээний зардал*

104. Өнгөрсөн үйлчилгээний зардал нь хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт эсвэл цомхотголын улмаас тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэд орсон өөрчлөлт юм.
105. **Байгууллага нь өнгөрсөн үйлчилгээний зардлыг дараах хугацааны аль түрүүнд болсон өдрөөр зардал гэж хүлээн зөвшөөрнө:**
  - (a) **Хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт эсвэл цомхотгол хийгдсэн өдөр; ба**
  - (б) **Байгууллага нь холбогдох бүтцийн өөрчлөлтийн зардал (УСНББОУС 19-ийг үзнэ үү) эсвэл ажлаас халагдалтын тэтгэмжийг (168-р параграфыг үзнэ үү) хүлээн зөвшөөрсөн өдөр.**
106. Байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийг нэвтрүүлсэн эсвэл цуцалсан, буюу одоо байгаа тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу төлөх тэтгэмжийг өөрчилсөн тохиолдолд хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт болно.
107. Байгууллага нь хөтөлбөрт хамрагдах ажилтнуудын тоог эрс бууруулсан тохиолдолд цомхотгол гэнэ. Үйлдвэрийг хаах, үйл ажиллагааг зогсоох, хөтөлбөрийг цуцлах эсвэл түдгэлзүүлэх гэх мэт хэвийн бус үйл явдлын улмаас цомхотгол хийж болох юм.
108. Өнгөрсөн үйлчилгээний зардал нь эерэг (тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд тэтгэмжийг шинээр нэвтрүүлсэн буюу өөрчилсөн тохиолдолд) эсвэл сөрөг (тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийг бууруулахын тулд тэтгэмжийг цуцалсан буюу өөрчилсөн тохиолдолд) байж болно.
109. Байгууллага нь одоо байгаа тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу олгох тэтгэмжийн өглөгийг бууруулах боловч тухайн ижил ажилтнуудад уг хөтөлбөрийн дагуу олгох бусад тэтгэмжийн өглөгийг үүнтэй нэгэн зэрэг нэмэгдүүлэх тохиолдолд энэхүү өөрчлөлтийг нэг цэвэр өөрчлөлт байдлаар тайлагнана.
110. Өнгөрсөн үйлчилгээний зардалд дараах зүйлс хамаарахгүй:
  - (a) Өмнөх жилүүдэд үзүүлсэн үйлчилгээний хувьд тэтгэмж төлөх тухайн үүрэгт цалингийн бодит болон урьдчилан төсөөлсөн өсөлтийн хоорондох зөрүүгийн үзүүлэх нөлөө (актуар төсөөлөлд төсөвлөсөн цалинг харгалзаж болох учраас өнгөрсөн үйлчилгээний зардал үүсэхгүй);
  - (б) Байгууллага нь тэтгэврийг ингэж нэмэгдүүлэх гэрээний бус үүрэгтэй тохиолдолд тэтгэврийн сайн дурын өсөлтийн талаархи илүү ба дутуу тооцоолол (актуар төсөөлөлд ийм өсөлтийг харгалзаж болох учраас өнгөрсөн үйлчилгээний зардал үүсэхгүй);

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

- (в) Хэдийгээр тэтгэмжийн өсөлтийг албан ёсоор зөвшөөрөн батлаагүй боловч байгууллага нь хөтөлбөрийн аливаа илүүдлийг тухайн хөтөлбөрт оролцогчдын тэтгэмжинд зориулан ашиглах үүргийг уг хөтөлбөрийн албан ёсны нөхцлөөр (буюу тэдгээр нөхцөлд үл хамаарах аливаа гэрээний бус үүргээр) эсвэл хуулиар хүлээсэн бол санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн хөтөлбөрийн хөрөнгийн үр өгөөжөөс эсвэл актуар олзоос үүсэх тэтгэмжийн нэмэгдүүлэлтийн тооцоолол (үүргийн холбогдох нэмэгдэлт нь актуар гарз болох учраас өнгөрсөн үйлчилгээний зардал үүсэхгүй, 90-р параграфыг үзнэ үү); ба
- (г) Шинэ буюу өөрчлөн сайжруулсан тэтгэмж байхгүй тохиолдолд ажилтнууд нь тэтгэмж авах эрхийн шаардлагуудыг биелүүлснээр уг баталгаат тэтгэмжинд (өөрөөр хэлбэл, тэтгэмж нь ирээдүйн ажил эрхлэлтээс үл хамаарна, 74-р параграфыг үзнэ үү) орсон нэмэгдэх өөрчлөлт (байгууллага нь тэтгэмжийн тооцоолсон зардлыг тухайн үйлчилгээг үзүүлмэгц одоогийн үйлчилгээний зардал гэж хүлээн зөвшөөрдөг тул өнгөрсөн үйлчилгээний зардал үүсэхгүй).

### *Барагдуулалтаас үүссэн олз, гарз*

- 111. Барагдуулалтаас үүссэн олз буюу гарз нь дараах дүнгүүдийн хоорондох зөрүү байна:
  - (а) Төлж барагдуулах уг тогтоосон тэтгэмжийн үүргийн тухайн барагдуулах өдрөөр тодорхойлсон өнөөгийн үнэ цэнэ; ба
  - (б) Барагдуулалтын үнэ, үүн дотроо хөтөлбөрийн аливаа шилжүүлсэн хөрөнгө ба уг барагдуулалттай холбоотойгоор тухайн байгууллагаас шууд хийсэн аливаа төлбөрүүд.
- 112. **Барагдуулалт хийсэн үед байгууллага нь уг тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн барагдуулалтаас үүссэн олз, гарзыг хүлээн зөвшөөрнө.**
- 113. Байгууллага нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу олгох бүх буюу зарим тэтгэмжийн хувьд хүлээх цаашдын бүх хуулийн эсвэл гэрээний бус үүргийг дуусгавар болгох ажил гүйлгээнд оролцсон тохиолдолд барагдуулалт хийгддэг (гэхдээ уг хөтөлбөрийн нөхцөлд заасан ба актуар төсөөлөлд харгалзан оруулсан, ажилтнуудад төлөх эсвэл тэдний өмнөөс төлөх тэтгэмжийн төлбөр үүнд хамаарахгүй). Жишээлбэл; уг хөтөлбөрийн дагуу хүлээх ажил олгогчийн томоохон үүргийг даатгалын гэрээ худалдан авах замаар даатгалын компанид шилжүүлэх нэг удаагийн шилжүүлт нь барагдуулалт болно; харин ажил эрхлэлтийн дараах тусгайлан заасан тэтгэмжийг авах уг хөтөлбөрийн оролцогчдын эрхийн хариуд тухайн хөтөлбөрийн нөхцлийн дагуу тэдгээр оролцогчдод бөөн дүнгээр олгох мөнгөн төлбөр нь барагдуулалт биш юм.
- 114. Зарим тохиолдолд байгууллага нь тухайн тайлант үед болон өмнөх тайлант үеүдэд ажилтны үзүүлсэн үйлчилгээтэй холбоотойгоор уг ажилтанд төлөх зарим буюу бүх тэтгэмжийг санхүүжүүлэхийн тулд даатгалын гэрээг худалдан авдаг. Хэрэв даатгагч нь даатгалын гэрээнд тусгайлан заасан ажилтны тэтгэмжүүдийг төлөхгүй бол тухайн байгууллага

нь цаашдын төлбөрийг төлөх хуулийн эсвэл гэрээний бус үүргийг хүлээх (48-р параграфыг үзнэ үү) тохиолдолд ийм даатгалын худалдан авалт нь барагдуулалт болохгүй юм. Даатгалын гэрээний дагуу хүлээн авах ба уг хөтөлбөрийн хөрөнгө болохгүй тийм нөхөн төлбөрийн эрхийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг 118-121-р параграфт авч үзсэн.

### **Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт-Хөтөлбөрийн хөрөнгө**

#### *Хөтөлбөрийн хөрөнгийн бодит үнэ цэнэ*

115. Дутагдал эсвэл илүүдлийг тодорхойлохын тулд тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнээс хөтөлбөрийн аливаа хөрөнгийн бодит үнэ цэнийг хасна.
116. Тайлагнагч байгууллагаас санд оруулах төлөгдөөгүй шимтгэл, түүнчлэн уг байгууллагын гаргасан бөгөөд сангийн эзэмшиж буй үл шилжүүлэгдэх аливаа санхүүгийн хэрэглүүр нь хөтөлбөрийн хөрөнгөнд хамаарахгүй. Ажилтны тэтгэмжтэй холбоогүй уг сангийн аливаа өр төлбөрөөр, тухайлбал худалдааны ба бусад өглөг, үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн өр төлбөр зэргээр тухайн хөтөлбөрийн хөрөнгийг бууруулна.
117. Хөтөлбөрийн хөрөнгө нь тухайн хөтөлбөрийн дагуу төлөх зарим буюу бүх тэтгэмжийн өглөгийн дүн ба хугацаатай яг тохирох тийм “шалгуур хангах даатгалын гэрээ”-г агуулж байгаа тохиолдолд тэрхүү даатгалын гэрээний бодит үнэ цэнийг уг холбогдох үүргийн өнөөгийн үнэ цэнэ гэж төсөөлөн үзнэ (хэрэв даатгалын гэрээний дагуу хүлээн авах дүн нь бүрэн нөхөн төлөгдөхөөргүй бол түүнд аливаа шаардлагатай бууралтыг тооцно).

#### *Нөхөн төлбөр*

118. **Тогтоосон тэтгэмжийн үүргийг барагдуулахад шаардлагатай бүх буюу зарим зарлагыг өөр нэг тал нөхөн төлнө гэдэг нь үнэхээр тодорхой байх зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь:**
  - (а) **Нөхөн төлбөр авах өөрийн эрхийг тусдаа хөрөнгө байдлаар хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь уг хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжинэ.**
  - (б) **Хөтөлбөрийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг авч үздэгтэй ижил арга замаар, уг нөхөн төлбөр авах өөрийн эрхийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, тусдаа тайлагнана (126 ба 128-р параграфыг үзнэ үү). 122-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн, тогтоосон тэтгэмжийн зардлын бүрэлдэхүүнийг нөхөн төлбөр авах эрхийн дансны үнийн өөрчлөлттэй уялдуулан цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрч болох юм.**
119. Зарим үед байгууллага нь тогтоосон тэтгэмжийн үүргийг барагдуулахад шаардлагатай зарим буюу бүх зарлагыг төлөхийн тулд даатгагч гэх мэт бусад талд хандах боломжтой байдаг. 8-р параграфт тодорхойлсончлон, шалгуур хангах даатгалын гэрээ нь хөтөлбөрийн хөрөнгө юм. Байгууллага

нь шалгуур хангах даатгалын гэрээг уг хөтөлбөрийн бусад бүх хөрөнгөтэй ижил арга замаар тайлагнах ба үүнд 118-р параграф хамаарахгүй (48-51, 117-р параграфыг үзнэ үү).

120. Байгууллагын эзэмшиж буй даатгалын гэрээ нь шалгуур хангах даатгалын гэрээ биш байх тохиолдолд уг даатгалын гэрээ нь хөтөлбөрийн хөрөнгө болохгүй. Ийм тохиолдолд 118-р параграфыг мөрдөнө: уг даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр авах өөрийн эрхийг байгууллага нь тухайн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дутагдал эсвэл илүүдлийг тодорхойлоход хамаарах хасагдах дүн гэж үзэхийн оронд тусдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь нөхөн төлбөр авах эрх ба холбогдох үүргийн хоорондох холбоо хамаарлын талаар товч тайлбар бүхий тодруулга хийхийг 142(б) параграфээр шаардсан байдаг.
121. Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу төлөх бүх буюу зарим тэтгэмжийн өглөгийн дүн ба хугацаатай яг нийцэх даатгалын гэрээ эсвэл хууль ёсоор заавал биелүүлэх хэлцлийн дагуу нөхөн төлбөр авах эрх үүсдэг бол уг нөхөн төлбөр авах эрхийн бодит үнэ цэнийг холбогдох үүргийн өнөөгийн үнэ цэнэ гэж үзнэ (хэрэв нөхөн төлбөрийг бүрэн олгохооргүй бол шаардлагатай аливаа бууруулалт хийнэ).

#### **Тогтоосон тэтгэмжийн зардлын бүрэлдэхүүн хэсгүүд**

122. **Өөр УСНББОУС нь тогтоосон тэтгэмжийн зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийг хөрөнгийн өртөгт оруулахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага нь тогтоосон тэтгэмжийн зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:**
- (а) Үйлчилгээний зардлыг ашиг, алдагдалд (68–114-р параграфыг үзнэ үү);
  - (б) Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүг ашиг, алдагдалд (125-128-р параграфыг үзнэ үү);
  - (в) Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөрийн дахин хэмжилтийг цэвэр хөрөнгө/өмчид (129–132-р параграфыг үзнэ үү).
123. Зарим УСНББОУС нь ажилтны зарим тэтгэмжийн зардлыг бараа материал, үндсэн хөрөнгө (УСНББОУС 12 ба УСНББОУС 17-г үзнэ үү) гэх мэт хөрөнгийн өртөгт тусган оруулахыг шаарддаг. Ийм хөрөнгүүдийн өртөгт багтсан, ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн аливаа зардал нь 122-р параграфт жагсаан харуулсан, бүрэлдэхүүн хэсгүүдийн зохих хэсгийг өөртөө агуулсан байна.
124. **Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн, тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилтийг дараагийн тайлант үед ашиг, алдагдал руу дахин ангилахгүй. Харин байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн тэдгээр дүнг цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийн дотор шилжүүлж болно.**

*Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүү*

125. **Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг 85-р параграфт тусгайлан заасан дискаунтын түвшнээр үржүүлснээр уг тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүг тодорхойлдог. Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө) ба дискаунтын түвшний аль алиныг уг тайлант үеийн эхэнд тодорхойлох бөгөөд шимтгэл болон тэтгэмжийн төлбөрийн үр дүнд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-г тухайн тайлант үеийн туршид орох аливаа өөрчлөлтийг эдгээрт харгалзан үзнэ.**
126. Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүү нь уг хөтөлбөрийн хөрөнгийн хүүний орлого, тогтоосон тэтгэмжийн үүргийн хүүний зардал болон 66-р параграфт дурдсан хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөний хүүнээс бүрддэг гэж үзэж болно.
127. Хөтөлбөрийн хөрөнгийн хүүний орлого нь уг хөтөлбөрийн хөрөнгийн өгөөжийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тухайн хөтөлбөрийн хөрөнгийн бодит үнэ цэнийг 85-р параграфт тусгайлан заасан дискаунтын түвшнээр үржүүлснээр үүнийг тодорхойлдог. Хөтөлбөрийн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба дискаунтын түвшний аль алиныг уг тайлант үеийн эхэнд тодорхойлох бөгөөд шимтгэл болон тэтгэмжийн төлбөрийн үр дүнд тухайн хөтөлбөрийн эзэмшиж буй хөрөнгөнд тайлант үеийн туршид орох аливаа өөрчлөлтийг эдгээрт харгалзан үзнэ. Хөтөлбөрийн хөрөнгийн хүүний орлого ба хөтөлбөрийн хөрөнгийн өгөөжийн хоорондох зөрүүг уг тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилтийн дүнд тусган оруулна.
128. Хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөний хүү нь хөрөнгийн дээд хязгаарын нийт өөрчлөлтийн нэг хэсэг бөгөөд уг хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөг 85-р параграфт тусгайлан заасан дискаунтын түвшнээр үржүүлснээр хүүг тодорхойлдог. Хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөө ба дискаунтын түвшний аль алиныг уг тайлант үеийн эхэнд тодорхойлно. Хүүний дүн ба хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөний нийт өөрчлөлтийн хоорондох зөрүүг тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилтийн дүнд тусган оруулдаг.

*Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилт*

129. Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилт нь дараах зүйлсээс бүрддэг:
- (а) Актуар олз, гарз (130 ба 131-р параграфыг үзнэ үү);
  - (б) Хөтөлбөрийн хөрөнгийн өгөөж (132-р параграфыг үзнэ үү), үүнд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүнд багтсан дүн хамаарахгүй (127-р параграфыг үзнэ үү);

- (в) Хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөний аливаа өөрчлөлт, үүнд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүнд багтсан дүн хамаарахгүй (128-р параграфыг үзнэ үү).
130. Актуар төсөөллийн өөрчлөлт ба туршлагад үндэслэсэн тохируулгын улмаас тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэд гарсан өсөлт буюу бууралтын үр дүнд актуар олз, гарз үүсдэг. Актуар олз, гарз үүсэх шалтгаанд тухайлбал, дараах зүйлс хамаарна:
- (а) Ажилтнуудын эргэц хөдөлгөөний хүлээгдээгүй өндөр буюу бага хувь хэмжээ, эрт тэтгэвэрт гаралт буюу нас баралт, цалин хөлс, тэтгэмж (хэрэв хөтөлбөрийн албан ёсны эсвэл гэрээний бус нөхцөл нь инфляцитай уялдуулан тэтгэмжийг нэмэгдүүлэхээр заасан бол), эрүүл мэндийн зардлын нэмэгдэлт;
- (б) Тэтгэмжийн төлбөрийн сонголтуудын талаархи төсөөллүүдэд эдгээр өөрчлөлтүүдийн үзүүлэх үр нөлөө;
- (в) Ажилтнуудын эргэц хөдөлгөөн, эрт тэтгэвэрт гаралт буюу нас баралт, цалин хөлс, тэтгэмж (хэрэв хөтөлбөрийн албан ёсны эсвэл гэрээний бус нөхцөл нь инфляцитай уялдуулан тэтгэмжийг нэмэгдүүлэхээр заасан бол), эрүүл мэндийн зардлын нэмэгдэлт гэх мэт ирээдүйн тооцооллууд дахь өөрчлөлтийн үр нөлөө;
- (г) Дискаунтын түвшний өөрчлөлтийн үр нөлөө.
131. Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн нэвтрүүлэлт, нэмэлт өөрчлөлт, цомхотгол, барагдуулалтын улмаас тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэд гарсан өөрчлөлт болон тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу төлөх тэтгэмжийн өглөгийн өөрчлөлт нь актуар олз, гарзад хамаарахгүй. Ийм өөрчлөлтүүд нь өнгөрсөн үйлчилгээний зардалд эсвэл барагдуулалтын олз, гарзад хамаарна.
132. Хөтөлбөрийн хөрөнгийн өгөөжийг тодорхойлохдоо, байгууллага нь уг хөтөлбөрийн хөрөнгийг удирдан зохицуулах зардал, түүнчлэн тогтоосон тэтгэмжийн үүргийг хэмжихэд ашигласан актуар төсөөллүүдэд багтсан татвараас бусад тухайн хөтөлбөрийн өөрийн төлөх аливаа татварыг хасаж тооцно (78-р параграф). Харин захиргаа удирдлагын бусад зардлуудыг хөтөлбөрийн хөрөнгийн өгөөжөөс хасахгүй.

## Толилуулга

### *Цэвэр дүн гаргах*

133. **Зөвхөн дараах тохиолдолд байгууллага нь нэг хөтөлбөрт хамаарах хөрөнгөөс нөгөө хөтөлбөрт хамаарах өр төлбөрийг хасаж, цэвэр дүнг гаргана:**
- (а) **Нэг хөтөлбөрийн илүүдлийг өөр хөтөлбөрийн үүргийг барагдуулахад ашиглах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй; ба**



- (б) Тухайн үүргийг цэвэр дүнгээр барагдуулах эсвэл нэг хөтөлбөрийн илүүдлийг хэрэгжүүлэх ба үүний хамтаар нөгөө хөтөлбөрийн үүргийг барагдуулахаар төлөвлөж байгаа.

134. Цэвэр дүн гаргах шалгуур нь УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга* дахь санхүүгийн хэрэглүүрийн хувьд тогтоосон шалгууртай ижил байна.

*Эргэлтийн/эргэлтийн бусын ялгаа*

135. Зарим байгууллага нь эргэлтийн хөрөнгө ба богино хугацаат өр төлбөрийг эргэлтийн бус хөрөнгө ба урт хугацаат өр төлбөрөөс ялгадаг. Байгууллага нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжээс үүссэн хөрөнгө, өр төлбөрийг эргэлтийн ба эргэлтийн бус гэж ялгах хэрэгтэй эсэхийг энэ Стандартад тусгайлан заагаагүй болно.

*Тогтоосон тэтгэмжийн зардлын бүрэлдэхүүн хэсгүүд*

136. 122-р параграф нь үйлчилгээний зардал болон тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхийг байгууллагаас шаарддаг. Байгууллага нь үйлчилгээний зардал болон тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүг хэрхэн толилуулахыг энэ Стандартад тусгайлан заагаагүй. Байгууллага нь эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийг УСНББОУС 1-ийн дагуу толилуулна.

**Тодруулга**

137. **Байгууллага нь дараах шинж бүхий мэдээллийг тодруулна:**

- (а) Түүний тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн шинж чанарууд ба тэдгээртэй холбоотой эрсдлүүдийг тайлбарлах (141-р параграфыг үзнэ үү);
- (б) Түүний тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрөөс үүссэн бөгөөд санхүүгийн тайланд тусгасан дүнгүүдийг тодорхойлж, тайлбарлах (142–146-р параграфыг үзнэ үү);
- (в) Түүний тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр нь байгууллагын ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн, хугацаа, тодорхойгүй байдалд хэрхэн нөлөөлж болохыг тайлбарлан тодорхойлох (147–149-р параграфыг үзнэ үү).

138. 137-р параграф дахь зорилтуудыг хангахын тулд байгууллага нь дараах зүйлсийг харгалзан үзвэл зохино:

- (а) Тодруулгын шаардлагуудыг хангахад шаардлагатай дэлгэрэнгүй байдлын түвшин;
- (б) Янз бүрийн шаардлага тус бүрд хэр их ач холбогдол өгөх эсэх;
- (в) Дүнг хэр их нэгтгэн нийлүүлэх эсвэл салган задлах эсэх;

- (г) Тодруулгад тусгасан тоон мэдээллийг үнэлэхийн тулд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд нэмэлт мэдээлэл шаардлагатай эсэх.
139. Хэрэв энэ Стандарт болон бусад УСНББОУС-ын шаардлагуудын дагуу хийсэн тодруулга нь 137-р параграф дахь зорилтуудыг ханган биелүүлэхэд хангалттай бус байвал байгууллага нь тэдгээр зорилтуудыг хангахад шаардлагатай нэмэлт мэдээллийг тодруулах хэрэгтэй. Тухайлбал; байгууллага нь тогтоосон тэтгэмжийн үүргийн төрөл, шинж чанар, эрсдлийг ялган зааглахын тулд уг үүргийн шинжилгээг толилуулж болох юм. Ийм тодруулга нь дараах байдлаар ялган тодорхойлох боломжтой байдаг:
- (а) Идэвхитэй гишүүд, түдгэлзүүлсэн гишүүд<sup>6</sup> болон тэтгэвэр авагчдад төлөх дүнгүүдийг өөр хооронд нь;
  - (б) Хуримтлагдсан боловч баталгаагүй тэтгэмж ба баталгаатай тэтгэмжийг өөр хооронд нь.
  - (в) Дүн нь ирээдүйн цалигийн өсөлтөөс хамаарах нөхцөлт тэтгэмж ба бусад тэтгэмжийг өөр хооронд нь.
140. Материаллаг хэмжээгээр ялгаатай эрсдлүүд бүхий хөтөлбөрүүд эсвэл хөтөлбөрүүдийн бүлгийг ялган тодорхойлохын тулд байгууллага нь бүх эсвэл зарим тодруулгыг салган задлах хэрэгтэй эсэхийг үнэлж дүгнэдэг. Тухайлбал; байгууллага нь хөтөлбөрийн талаархи тодруулгыг дараах нэг буюу хэд хэдэн шинжийг харуулах байдлаар салган задалж болох юм:
- (а) Газар зүйн өөр өөр байршлууд.
  - (б) Тогтмол цалинт тэтгэврийн хөтөлбөр, сүүлийн жилийн цалинт тэтгэврийн хөтөлбөр эсвэл ажил эрхлэлтийн дараах эрүүл мэндийн хөтөлбөр гэх мэт янз бүрийн шинж чанарууд.
  - (в) Эрх зүйн зохицуулалтын янз бүрийн орчин.
  - (г) Тайлагналын янз бүрийн сегментүүд.
  - (д) Санхүүжилтийн өөр өөр хэлцлүүд (жишээлбэл; бүрэн санхүүжигдээгүй, бүрэн эсвэл хэсэгчлэн санхүүжигдсэн).

*Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн шинж чанарууд ба тэдгээртэй холбоотой эрсдлүүд*

141. Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Өөрийн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн шинж чанаруудын талаархи мэдээлэл. Үүнд:

---

<sup>6</sup> Deferred member-Түдгэлзүүлсэн гишүүн гэдэг нь хөтөлбөрт шимтгэл төлөхөө зогсоосон боловч тэтгэвэр хараахан авч эхлээгүй байгаа гишүүн юм. Ийм гишүүний тэтгэмж түдгэлзсэн боловч тэрээр одоо хүртэл хуримтлагдсан тэтгэмжийн талаархи жил тутмын тайланг хүлээн авах эрхтэй байдаг. Ред Ч.Д.

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

- (i) Хөтөлбөрөөр олгох тэтгэмжийн төрөл (жишээ нь; сүүлийн жилийн цалинт тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр эсвэл шимтгэлд суурилсан баталгаа бүхий хөтөлбөр).
  - (ii) Тухайн хөтөлбөрийн үйл ажиллагаагаа явуулдаг эрх зүйн зохицуулалтын хүрээний тайлбар тодорхойлолт, тухайлбал; аливаа санхүүжилтийн хамгийн наад захын шаардлагуудын түвшин ба хөтөлбөрийн хөрөнгийн дээд хязгаар гэх мэт уг хөтөлбөрт зохицуулалтын хүрээний үзүүлэх аливаа үр нөлөө (66-р параграфыг үзнэ үү).
  - (iii) Тухайн хөтөлбөрийн засаглалын хувьд аливаа бусад байгууллагын хүлээх хариуцлагын талаархи тайлбар тодорхойлолт, жишээ нь; хөтөлбөрийн итгэмжлэгдсэн этгээдийн эсвэл удирдах зөвлөлийн гишүүдийн хариуцлага.
- (б) Хөтөлбөрийн улмаас байгууллагад учрах эрсдлийн тайлбар тодорхойлолт, энэ нь байгууллагын тусгайлсан эсвэл хөтөлбөрийн тусгай аливаа хэвийн бус эрсдлүүдэд голлон чиглэнэ, мөн эрсдлийн аливаа мэдэгдэхүйц төвлөрлийн талаархи тайлбар тодорхойлолт. Тухайлбал; хөтөлбөрийн хөрөнгөөр голчлон хөрөнгө оруулалтын нэг ангид, жишээлбэл үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийсэн бол уг хөтөлбөр нь үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн төвлөрлийн эрсдэлд тухайн байгууллагыг өртүүлж болох юм.
- (в) Хөтөлбөрийн аливаа нэмэлт өөрчлөлт, цомхотгол, барагдуулалтын талаархи тайлбар тодорхойлолт.
- (г) Дискаунтын түвшинг тодорхойлоход ашигласан суурь үндэслэл.

### *Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийн тайлбар*

142. Хэрэв боломжтой бол байгууллага нь дараах зүйл тус бүрийн хувьд эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдэл хүртэлх тохируулгыг бэлтгэнэ:
- (а) Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө), доорх зүйлсийн хувьд тусдаа тохируулгыг харуулах:
    - (i) Хөтөлбөрийн хөрөнгө.
    - (ii) Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ.
    - (iii) Хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөө.
  - (б) Аливаа нөхөн төлбөр авах эрх. Байгууллага нь нөхөн төлбөр авах эрх ба түүнд хамаарах үүргийн хоорондох харилцан холбоог бас тайлбарлан тодорхойлдог.
143. Хэрэв боломжтой бол 142-р параграфт дурдсан тохируулга бүрд дараах зүйл тус бүрийг харуулна:
- (а) Одоогийн үйлчилгээний зардал.
  - (б) Хүүний орлого эсвэл зардал.

- (в) Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилт, үүнд доорх зүйлсийг тусдаа харуулна:
    - (i) Хөтөлбөрийн хөрөнгийн өгөөж, үүнд дээрх (б)-д дурдсан хүүнд багтсан дүн хамаарахгүй.
    - (ii) Хүн ам зүйн төсөөллүүдийн өөрчлөлтөөс бий болсон актуар олз, гарз (78(а) параграфыг үзнэ үү).
    - (iii) Санхүүгийн төсөөллүүдийн өөрчлөлтөөс бий болсон актуар олз, гарз (78(б) параграфыг үзнэ үү).
    - (iv) Тогтоосон тэтгэмжийн цэвэр хөрөнгийг тухайн хөтөлбөрийн хөрөнгийн дээд хязгаарт багтаан хязгаарласны үр нөлөөний өөрчлөлт, үүнд дээрх (б)-д дурдсан хүүнд багтсан дүн хамаарахгүй. Байгууллага нь боломжит эдийн засгийн хамгийн их үр өгөөжийг хэрхэн тодорхойлсныг, өөрөөр хэлбэл, эдгээр өгөөж нь буцаан олголт, ирээдүйн шимтгэлийн бууралт эсвэл энэ хоёрын хослол хэлбэрээр байх эсэхийг мөн тодруулна.
  - (г) Өнгөрсөн үйлчилгээний зардал ба барагдуулалтаас үүссэн олз, гарз. 102-р параграфтаар зөвшөөрсөнчлөн, хэрэв өнгөрсөн үйлчилгээний зардал ба барагдуулалтаас үүссэн олз, гарз нь хамтдаа гарч тохиолдсон бол тэдгээрийг салган зааглах шаардлагагүй юм.
  - (д) Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө.
  - (е) Хөтөлбөрт оруулсан шимтгэлүүд, үүнд ажил олгогч ба хөтөлбөрийн оролцогчдын оруулсан шимтгэлүүдийг тусдаа харуулах.
  - (ж) Хөтөлбөрөөс хийсэн төлбөрүүд, үүнд аливаа барагдуулалтын хувьд төлсөн дүнг тусдаа харуулах.
  - (и) Улсын секторын нэгдэл ба нэгдлийн данснаас хасалтын үр нөлөө.
144. Хөтөлбөрийн хөрөнгийн шинж төрөл ба эрсдлээс хамааран ялгаатай байх ангиудаар байгууллага нь уг хөтөлбөрийн хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг салган зааглах, түүнчлэн идэвхитэй зах зээл дэх жишиг зах зээлийн үнэтэй эсвэл ийм жишиг зах зээлийн үнэгүй гэдгээр хөтөлбөрийн хөрөнгийн анги нэг бүрийг ялган хуваах хэрэгтэй. Жишээлбэл; 138-р параграфт авч үзсэн тодруулгын түвшнийг харгалзснаар байгууллага нь дараах зүйлсийг ялган зааглаж болно:
- (а) Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө;
  - (б) Өмчийн хэрэглүүр (салбарын төрөл, компанийн хэмжээ, газарзүйн байршил зэргээр ялган заагласан);
  - (в) Өрийн хэрэглүүр (гаргагчийн төрөл, зээлийн чанар, газар зүйн байршил зэргээр ялган заагласан);
  - (г) Үл хөдлөх хөрөнгө (газар зүйн байршил зэргээр ялган заагласан);
  - (д) Үүсмэл хэрэглүүр (гэрээнд заасан суурь эрсдлийн төрлөөр ялган заагласан. Тухайлбал, хүүний хувь хэмжээний гэрээ, гадаад валютын

ханшийн гэрээ, өмчийн гэрээ, зээлийн гэрээ, удаан амьдралын своп гэрээ<sup>7</sup>);

- (е) Хөрөнгө оруулалтын сан (сангийн төрлөөр ялган заагласан);
- (ж) Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;
- (и) Бүтэцчилсэн өрийн үнэт цаас.

145. Байгууллага нь хөтөлбөрийн хөрөнгө байдлаар эзэмшиж буй уг байгууллагын өөрийн шилжүүлэгдэх санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ ба өөрийн эзэмшиж байгаа үл хөдлөх хөрөнгө болон тухайн хөтөлбөрийн хөрөнгө эсвэл ашиглаж буй бусад хөрөнгийн бодит үнэ цэнийг тодруулах хэрэгтэй.
146. Байгууллага нь тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход ашигласан томоохон актуар төсөөллүүдийг мөн тодруулах хэрэгтэй (78-р параграфыг үзнэ үү). Ийм тодруулга нь үнэмлэхүй утгаар байвал зохино (жишээлбэл, үнэмлэхүй хувийн жингээр байх, харин өөр өөр хувийн жингүүд ба бусад хувьсагчдын цэвэр зөрүүгээр биш). Хөтөлбөрийн бүлгүүдийн хувьд нийт дүнгээр тодруулгыг хийх тохиолдолд байгууллага нь уг тодруулгыг жинэлсэн дундаж эсвэл харьцангуй нарийвчилсан муж хэлбэрээр илэрхийлвэл зохино.

*Ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн, хугацаа ба тодорхойгүй байдал*

147. Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Тайлант үеийн эцсээрх томоохон актуар төсөөлөл тус бүрийн хувьд хийсэн мэдрэмжийн шинжилгээ (146-р параграфт тодруулсны дагуу). Үүнд: тухайн өдрөөр үл үндэслэлтэйгээр боломжтой байсан холбогдох актуар төсөөллийн өөрчлөлт нь тогтоосон тэтгэмжийн үүрэгт хэрхэн нөлөөлөх байсныг харуулах.
  - (б) Дээрх (а)-д шаардсан мэдрэмжийн шинжилгээг хийхдээ ашигласан арга ба төсөөллүүд, түүнчлэн тэдгээр аргуудын хязгаарлагдмал байдал.
  - (в) Мэдрэмжийн шинжилгээ хийхдээ ашигласан арга ба төсөөллүүдэд өмнөх тайлант үеэс хойш гарсан өөрчлөлтүүд болон тийм өөрчлөлтийн учир шалтгаан.
148. Байгууллага нь өөрөө болон уг хөтөлбөрийн ашигласан хөрөнгө-өр төлбөрийг уялдуулах аливаа стратегийн утга агуулгыг, үүн дотроо тогтмол мөнгө, түүнчлэн эрсдлийг удирдахын тулд ашигласан удаан амьдралын своп гэрээ гэх мэт бусад арга зүйн хэрэглээг тодруулна.

---

<sup>7</sup> Longevity swap-Удаан амьдралын своп гэрээ гэдэг нь хэвийн хүлээгдэж буй хугацаанаас урт хугацаагаар амьдрах тэтгэвэр авагчид тэтгэвэр төлөх эрсдлийг хөрөнгө оруулалтын банк, даатгалын компани гэх мэт гуравдагч талд шилжүүлэх гэрээ юм. Ред Ч.Д.

149. Байгууллагын ирээдүйн мөнгөн гүйлгээнд уг тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн үзүүлэх үр нөлөөг харуулахын тулд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (a) Ирээдүйн шимтгэлд нөлөөлөх аливаа санхүүжилтийн хэлцэл болон санхүүжилтийн бодлогын тайлбар тодорхойлолт.
  - (б) Дараагийн тайлант үед уг хөтөлбөрт оруулахаар хүлээгдэж буй шимтгэл.
  - (в) Тогтоосон тэтгэмжийн үүргийг дуусгавар болгох төлбөрийн талаархи мэдээлэл. Үүнд тогтоосон тэтгэмжийн үүргийн жинэлсэн дундаж хугацааг тусгах бөгөөд тэтгэмжийн төлбөрийн дуусгавар болох хугацааны шинжилгээ гэх мэт тэтгэмжийн төлбөрүүдийн хугацааны хуваарилалтын талаархи бусад мэдээллийг тусгаж болох юм.

*Олон ажил олгогчийн хөтөлбөр*

150. Хэрэв байгууллага нь олон ажил олгогчийн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрт оролцдог бол тэрээр дараах зүйлсийг тодруулна:
- (a) Санхүүжилтийн хэлцлийн тайлбар тодорхойлолт, үүнд: тухайн байгууллагын шимтгэлийн хувь хэмжээ болон санхүүжилтийн аливаа наад захын хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход ашигласан арга.
  - (б) Олон ажил олгогчийн хөтөлбөрийн нөхцөл, болзлын дагуу бусад байгууллагуудын үүрэгтэй холбоотойгоор уг байгууллага нь тухайн хөтөлбөрийн хувьд хүлээх үүргийн хэмжээний талаархи тайлбар тодорхойлолт.
  - (в) Дараах тохиолдолд дутагдал эсвэл илүүдлийг хуваарилах аливаа тохиролцооны тайлбар тодорхойлолт:
    - (i) Хөтөлбөрийг татан буулгах; эсвэл
    - (ii) Тухайн байгууллага нь хөтөлбөрөөс татгалзаж гарах.
  - (г) Хэрэв байгууллага нь 34-р параграфын дагуу уг хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөртэй адилтган үзэж, тайлагнах бол 141-149-р параграфтаар шаардсан мэдээллийг биш, харин дээрх (а)–(в)-д шаардсан мэдээллээс гадна дараах зүйлсийг тодруулна:
    - (i) Уг хөтөлбөр нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр болох тухай.
    - (ii) Байгууллага нь уг хөтөлбөрийг тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр гэж тайлагнах боломж олгох хангалттай мэдээлэл яагаад бэлэн байхгүй байгаагийн учир шалтгаан.
    - (iii) Дараагийн тайлант үед уг хөтөлбөрт оруулахаар хүлээгдэж буй шимтгэл.
    - (iv) Ирээдүйн шимтгэлийн дүнд нөлөөлж болох уг хөтөлбөрийн аливаа дутагдал эсвэл илүүдлийн талаархи мэдээлэл, үүн дотроо дутагдал эсвэл илүүдлийг тодорхойлоход ашигласан

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

суурь, түүнчлэн хэрэв тухайн байгууллагад ямар нэг нөлөөтэй бол түүний ач холбогдол.

- (v) Уг хөтөлбөр дэх тухайн байгууллагын оролцооны түвшинг бусад оролцогч байгууллагуудтай харьцуулах харуулалт. Ийм харьцуулан илэрхийлэлтээр хангаж болох хэмжүүр үзүүлэлтийн жишээ нь; хөтөлбөрийн нийт шимтгэлд тухайн байгууллагын эзэлж байгаа хувь хэмжээ, хэрэв холбогдох мэдээлэл байгаа бол идэвхитэй гишүүд, тэтгэвэрт гарсан гишүүд, тэтгэмж авах эрх олгогдсон хуучин гишүүдийн нийт тоонд уг байгууллагын эзлэх хувь хэмжээ.

*Ерөнхий хяналтанд буй байгууллагуудад эрсдлийг хуваах тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр*

- 151. Хэрэв байгууллага нь ерөнхий хяналтанд буй байгууллагуудад эрсдлийг хуваах тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрт оролцдог бол тэрээр дараах зүйлсийг тодруулах хэрэгтэй:
  - (a) Тогтоосон тэтгэмжийн цэвэр зардлыг хуваарилан нэхэмжлэх талаархи гэрээний тохиролцоо буюу тогтоосон бодлого, хэрэв ийм бодлого байхгүй бол энэ тухай.
  - (б) Уг байгууллагын төлөх шимтгэлийн дүнг тодорхойлох бодлого.
  - (в) Хэрэв байгууллага нь тогтоосон тэтгэмжийн цэвэр зардлын хуваарилалтыг 41-р параграфт заасны дагуу тайлагнадаг бол 137-139-р параграфтаар бүхэлдээ шаардсан, уг хөтөлбөрийн талаархи бүх мэдээлэл.
  - (г) Хэрэв байгууллага нь тухайн тайлант үеийн шимтгэлийн өглөгийг 41-р параграфт заасны дагуу тайлагнадаг бол 137-139, 141, 144-146, 149(a), (б) параграфтаар бүхэлдээ шаардсан, уг хөтөлбөрийн талаархи бүх мэдээлэл.
- 152. Дараах тохиолдолд тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллага дахь өөр байгууллагын санхүүгийн тайлан дахь тодруулгатай харилцан лавлагаа үүсгэснээр 151(в), (г) параграфтаар шаардсан мэдээллийг тодруулж болно:
  - (a) Уг хөтөлбөрийн талаархи шаардлагатай мэдээллийг тус эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх тэрхүү байгууллагын санхүүгийн тайланд тусдаа тодорхойлж, тодруулдаг;
  - (б) Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх тэрхүү байгууллагын санхүүгийн тайлан нь тухайн байгууллагын санхүүгийн тайлантай ижил нөхцлөөр, түүнчлэн тухайн байгууллагын санхүүгийн тайлантай ижил буюу арай өмнөх хугацаанд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ашиглагдах боломжтой байх.

*Бусад УСНББОУС-ууд дахь тодруулгын шаардлагууд*

- 153. УСНББОУС 20-оор шаардсан тохиолдолд байгууллага нь дараах зүйлсийн талаархи мэдээллийг тодруулна:

- (a) Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөртэй хийгдсэн холбоотой талуудын ажил гүйлгээ;
  - (б) Эрх бүхий албан тушаалтны ажил эрхлэлтийн дараах тэтгэмж.
154. УСНББОУС 19-өөр шаардсан тохиолдолд байгууллага нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн үүргээс үүссэн болзошгүй өр төлбөрийн талаархи мэдээллийг тодруулна.

### **Ажилтны урт хугацааны бусад тэтгэмж**

155. Ажилтан холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант үеийн эцсээс хойш арван хоёр сарын дотор бүрэн төлөгдөхөөр хүлээгдээгүй бол дараах гэх мэт зүйлсийг ажилтны урт хугацааны бусад тэтгэмжид хамруулна:
- (a) Удаан хугацаагаар ажилласны амралт буюу саббатикал амралт гэх мэт урт хугацааны цалинтай чөлөө;
  - (б) Ойн баярын буюу удаан хугацаанд ажилласны бусад тэтгэмж;
  - (в) Удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж;
  - (г) Ашиг хуваалт ба шагнал урамшуулал;
  - (д) Хойшлогдсон цалин хөлс;
  - (e) Тухайн хувь хүн нь шинэ ажилд орох хүртэл уг байгууллагаас олгох нөхөн төлбөрийн өглөг.
156. Ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хэмжилт нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хэмжилттэй адил тийм их тодорхой бус байдалд ихэвчлэн хамаардаггүй. Ийм учраас энэ Стандарт нь ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийг бүртгэхдээ хялбаршуулсан арга ашиглахыг шаарддаг. Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хувьд хэрэглэх нягтлан бодох бүртгэлээс ялгаатай тал нь уг аргын дагуу дахин хэмжилтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөхгүй.
157. Удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийн төлбөр нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хэмжилттэй адил тийм тодорхойгүй байдлын зэрэг хэмжээтэй байдаггүй гэсэн няцааж болох урьдчилсан нөхцлийг энэхүү Стандартад тусгасан байдаг. Энэхүү урьдчилсан нөхцөл няцаагдсан тохиолдолд уг байгууллага нь удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны бүх буюу зарим төлбөрийг 57-154-р параграфын дагуу тайлагнах хэрэгтэй эсэхийг харгалзан үзнэ.

### **Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт**

158. **Ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хөтөлбөрийн илүүдэл буюу дутагдлыг хүлээн зөвшөөрч, хэмжихдээ байгууллага нь 58-100, 115-117-р параграфыг дагаж мөрдөнө. Байгууллага нь нөхөн төлбөрийн аливаа эрхийг хүлээн зөвшөөрч, хэмжихдээ 118-121-р параграфыг мөрдөнө.**



159. **Өөр УСНББОУС нь дараах зүйлсийг хөрөнгийн өртөгт оруулахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага нь ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хувьд дараах зүйлсийг цэвэр дүнгээр нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Үйлчилгээний зардал (68-114-р параграфыг үзнэ үү);**
  - (б) **Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүү (125-128-р параграфыг үзнэ үү); ба**
  - (в) **Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилт (129-132-р параграфыг үзнэ үү).**
160. Ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн нэг хэлбэр нь удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж юм. Хэрэв тэтгэмжийн түвшин нь үйлчилгээний хугацааны уртаас хамаардаг бол уг үйлчилгээг үзүүлсэн тохиолдолд үүрэг үүснэ. Ийм үүргийн хэмжилт нь төлбөрийг шаардах магадлал ба төлбөрийг хийхээр хүлээгдэж буй хугацааны уртыг тусгадаг. Хэрэв тэтгэмжийн түвшин нь хөдөлмөрийн чадвараа алдсан аливаа ажилтны хувьд үйлчилгээний (ажилласан) жилээс үл хамааран ижил байвал удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдахад хүргэх тийм үйл явдал тохиолдсон үед тэдгээр тэтгэмжийн хүлээгдэж буй зардлыг хүлээн зөвшөөрнө.

### **Тодруулга**

161. Хэдийгээр энэ Стандарт нь ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн талаар тусгай тодруулга хийхийг шаарддаггүй боловч бусад УСНББОУС нь тодруулга хийхийг шаардаж болох юм. Тухайлбал; УСНББОУС 20 нь эрх бүхий албан тушаалтны тэтгэмжийн талаар тодруулга хийхийг шаарддаг. УСНББОУС 1 нь ажилтны тэтгэмжийн зардлын талаар тодруулга хийхийг шаарддаг.

### **Ажлаас халагдалтын тэтгэмж**

162. Ажлаас халагдалтын тэтгэмж төлөх үүрэг үүсгэх үйл явдал нь ажилтны үзүүлсэн үйлчилгээ биш, харин ажил эрхлэлтийг дуусгавар болголт учраас энэхүү Стандарт нь ажлаас халагдалтын тэтгэмжийг ажилтны бусад тэтгэмжүүдээс тусад нь авч үздэг. Ажлаас халагдалтын тэтгэмж нь ажил эрхлэлтийг дуусгавар болгох байгууллагын шийдвэр эсвэл ажил эрхлэлтийг дуусгавар болгосны хариуд тэтгэмж олгох уг байгууллагын саналыг хүлээн зөвшөөрсөн ажилтны шийдвэрийн үр дүн байдаг.
163. Байгууллагаас санал гаргаагүй боловч тухайн ажилтны хүсэлтээр эсвэл тэтгэвэрт гарах албан журмын шаардлагуудын үр дүнд ажил эрхлэлтийг дуусгавар болгосноор үүссэн ажилтны тэтгэмжүүд нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болох тул тэдгээрийг ажлаас халагдалтын тэтгэмжинд хамруулахгүй. Зарим байгууллага нь ажилтны хүсэлтээр ажил эрхлэлтийг дуусгавар болгосон тохиолдолд олгох тэтгэмжийг (мөн чанарын хувьд ажил эрхлэлтийн дараах тэтгэмж) тухайн байгууллагын хүсэлтээр ажил эрхлэлтийг дуусгавар болгосноор олгох тэтгэмжээс арай багаар тогтоодог.

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

Ажилтны хүсэлтээр ажил эрхлэлтийг дуусгавар болгосноор олгох тэтгэмж ба тухайн байгууллагын хүсэлтээр ажил эрхлэлтийг дуусгавар болгосноор олгох арай өндөр тэтгэмжийн хоорондох зөрүү нь ажлаас халсаны тэтгэмж болох юм.

164. Ажилтны тэтгэмжийг олгох хэлбэр нь уг тэтгэмжийг үзүүлсэн үйлчилгээний хариуд эсвэл ажилтны ажил эрхлэлтийг дуусгавар болгосны хариуд олгож байгаа эсэхийг тодорхойлохгүй. Ажлаас халагдалтын тэтгэмж нь ихэвчлэн бөөн дүнгээр олгох төлбөр боловч зарим үед мөн дараах зүйлсийг агуулсан байдаг:
- (а) Ажилтны тэтгэмжийн хөтөлбөрөөр дамжуулан шууд бусаар эсвэл шууд олгох ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн нэмэгдэл.
  - (б) Хэрэв ажилтан нь тухайн байгууллагад эдийн засгийн үр өгөөж бий болгох үйлчилгээг цаашид үзүүлэхгүй бол тусгайлан заасан мэдэгдлийн хугацааны эцэс хүртэл олгох цалин.
165. Ажилтны тэтгэмжийг түүний үзүүлсэн үйлчилгээний хариуд олгож байгаа гэдгийг илэрхийлэх үзүүлэлтэнд дараах зүйлс хамаарна:
- (а) Уг тэтгэмж нь үзүүлэх ирээдүйн үйлчилгээнээс нөхцөлт хамааралтай байх (хэрэв үйлчилгээг цаашид үзүүлвэл нэмэгдүүлэх тэтгэмж үүнд хамаарна).
  - (б) Тэтгэмжийг ажилтны тэтгэмжийн хөтөлбөрийн нөхцлийн дагуу олгож байх.
166. Ажлаас халагдалтын зарим тэтгэмжийг ажилтны одоо мөрдөж буй тэтгэмжийн хөтөлбөрийн нөхцлүүдийн дагуу олгодог. Тухайлбал; энэ талаар хууль эрх зүйн акт, хөдөлмөрийн гэрээ, үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан хэлэлцээрт тусгайлан заасан эсвэл адилтгах тэтгэмжийг олгож байсан уг ажил ологчийн өнгөрсөн практикын үр дүнд ийм тэтгэмж олгоно гэж ойлгогдохоор байж болох юм. Өөр нэг жишээ; хэрэв байгууллага нь богино биш хугацаанд авах боломжтой тэтгэмжийн саналыг гаргасан бөгөөд уг санал ба бодитойгоор ажлаас халагдах хүлээгдэж буй хугацааны хооронд богино биш хугацаа байвал тухайн байгууллага нь ажилтны тэтгэмжийн шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх эсэх, ингэснээр тэрхүү хөтөлбөрийн дагуу санал болгох тэтгэмж нь ажлаас халагдалтын тэтгэмж эсвэл ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болох эсэхийг харгалзан үзнэ. Ажилтны тэтгэмжийн хөтөлбөрийн нөхцлүүдийн дагуу олгох ажилтны тэтгэмж нь тухайн ажилтны ажил эрхлэлтийг дуусгавар болгох уг байгууллагын шийдвэрийн үр дүн ба ирээдүйд үзүүлэх үйлчилгээнээс хамаарахгүй байх аль аль тохиолдолд энэ нь ажлаас халагдалтын тэтгэмж болно.
167. Ажилтны зарим тэтгэмжийг тухайн ажилтны ажлаас гарах шалтгаанаас үл хамааран олгодог. Ийм тэтгэмжийн төлбөрийн дүн нь тодорхой (баталгаатай эсвэл үйлчилгээ үзүүлэх хамгийн наад захын аливаа шаардлагуудад захирагдана) боловч тэдгээр төлбөрийг төлөх хугацаа нь тодорхой бус байдаг. Ийм тэтгэмжийг зарим улс оронд ажлаас

халагдалтын нөхөн төлбөр эсвэл ажлаас халагдалтын мөнгөн тэтгэмж гэх мэтээр нэрлэдэг боловч энэ нь ажлаас халагдалтын тэтгэмж биш, харин ажил эрхлэлтийн дараах тэтгэмж бөгөөд байгууллага нь үүнийг ажил эрхлэлтийн дараах тэтгэмж гэж тайлагнана.

### Хүлээн зөвшөөрөлт

168. **Байгууллага нь ажлаас халагдалтын тэтгэмжийн хувьд өр төлбөр ба зардлыг дараах хугацааны аль түрүүнд болох өдрөөр хүлээн зөвшөөрнө:**
- (a) **Байгууллага нь эдгээр тэтгэмжийг санал болгохоос цаашид татгалзаж чадахгүй болсон үед;**
  - (b) **Байгууллага нь бүтцийн өөрчлөлтийн зардлыг УСНББОУС 19-ийн цар хүрээний дагуу хүлээн зөвшөөрсөн ба ажлаас халагдалтын тэтгэмжийн төлбөрийг үүнд оруулсан үед.**
169. Ажил эрхлэлтийг дуусгавар болгосны хариуд тэтгэмж олгох саналыг хүлээн зөвшөөрсөн ажилтны шийдвэрийн үр дүн болох ажлаас халагдалтын тэтгэмжийн өглөгийн хувьд, байгууллага ажлаас халагдалтын тэтгэмжийн уг саналаасаа цаашид татгалзаж чадахгүй болох хугацаа нь дараах хоёр өдрийн аль түрүүнд болох өдөр юм:
- (a) Саналыг ажилтан хүлээн авч, зөвшөөрсөн өдөр; ба
  - (b) Байгууллага өөрийн саналаасаа татгалзах боломжинд тавигдах хязгаарлалт (жишээлбэл; хуулийн, зохицуулалтын буюу гэрээний шаардлагууд эсвэл бусад хязгаарлалтууд) хүчин төгөлдөр болсон өдөр. Хэрэв санал болгох үед ийм хязгаарлалт угаасаа байсан бол уг саналыг гаргаснаар хязгаарлалт хүчин төгөлдөр болох юм.
170. Ажил эрхлэлтийг дуусгавар болгох байгууллагын шийдвэрийн үр дүн болох ажлаас халагдалтын тэтгэмжийн өглөгийн хувьд, байгууллага нь дараах бүх шалгуурыг хангасан, ажлаас халах арга хэмжээгээ холбогдох ажилтнуудад хүргэн танилцуулсан өдрөөр уг байгууллага нь саналаасаа цаашид татгалзаж чадахааргүй болно:
- (a) Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа нь уг арга хэмжээнд мэдэгдэхүйц өөрчлөлт хийх магадлалгүй гэдгийг илэрхийлэх.
  - (b) Уг арга хэмжээ нь ажил эрхлэлтийг дуусгавар болгож буй ажилтнуудын тоо, тэдний ажлын ангилал буюу үүрэг ажиллагаа, байршил (гэхдээ арга хэмжээнд ажилтан нэг бүрээр тусгайлан заах шаардлагагүй) болон арга хэмжээг хэрэгжүүлж дуусгах хүлээгдэж буй хугацааг тодорхойлон заах.
  - (в) Арга хэмжээ нь уг ажилтан ажлаас халагдсан тохиолдолд өөрийн авах тэтгэмжийн төрөл ба дүнг тодорхойлж чадахуйц тийм хангалттай дэлгэрэнгүй байдлаар тэдний авах ажлаас халагдалтын тэтгэмжийг тогтоосон байх.

171. Байгууллага нь ажлаас халагдалтын тэтгэмжийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд уг байгууллага нь ажилтны бусад тэтгэмжийн хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт буюу цомхотголыг мөн тайлагнах шаардлагатай байж болно (105-р параграфыг үзнэ үү).

#### **Хэмжилт**

172. **Байгууллага нь ажлаас халагдалтын тэтгэмжийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжих ба дараагийн тайлант үеүд дэх өөрчлөлтийг ажилтны тэтгэмжийн шинж төрлийн дагуу хүлээн зөвшөөрнө. Хэрэв ажлаас халагдалтын тэтгэмж нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн нэмэгдүүлэлт бол уг байгууллага нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжинд хамаарах шаардлагуудыг даган мөрдөнө. Үүнээс бусад тохиолдолд:**
- (a) **Хэрэв ажлаас халагдалтын тэтгэмжийг хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн эцсээс хойш арван хоёр сарын дотор уг ажлаас халагдалтын тэтгэмжийг бүрэн барагдуулахаар хүлээгдэж байгаа бол байгууллага нь ажилтны богино хугацааны тэтгэмжинд хамаарах шаардлагуудыг даган мөрдөнө.**
  - (б) **Хэрэв ажлаас халагдалтын тэтгэмжийг тайлант үеийн эцсээс хойш арван хоёр сарын дотор бүрэн барагдуулахаар хүлээгдээгүй бол байгууллага нь ажилтны урт хугацааны бусад тэтгэмжинд хамаарах шаардлагуудыг даган мөрдөнө.**
173. Ажлаас халагдалтын тэтгэмжийг үзүүлсэн үйлчилгээний хариуд олгодоггүй учраас үйлчилгээ үзүүлсэн тайлант үеүдэд тэтгэмжийг хамааруулан хуваарилахтай холбоотой 72-76-р параграфыг үүнд мөрдөхгүй юм.

#### **Тодруулга**

174. Энэ Стандарт нь ажлаас халагдалтын тэтгэмжийн талаар тусгай тодруулга хийхийг шаардаагүй боловч өөр бусад УСНББОУС-ууд нь ийм тодруулга хийхийг шаардаж болох юм. Тухайлбал, УСНББОУС 20 нь эрх бүхий албан тушаалтны тэтгэмжийн талаар тодруулга хийхийг шаарддаг. УСНББОУС 1 нь ажилтны тэтгэмжийн зардлын талаар тодруулга хийхийг шаарддаг.

#### **Шилжилтийн нөхцөл**

175. **Доор дурдсанаас бусад тохиолдолд байгууллага нь энэ Стандартыг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу буцаах горимоор мөрдөнө:**
- (a) **Энэ Стандартыг анх мөрдөхөөс өмнө бөгөөд түүний цар хүрээнд хамаарахгүй тийм хөрөнгийн дансны үнэд тусган оруулсан ажилтны тэтгэмжийн зардлын өөрчлөлтүүдийн хувьд байгууллага нь тухайн хөрөнгийн дансны үнийг тохируулах шаардлагагүй. Анх мөрдөх өдөр нь энэхүү Стандартыг уг**

байгууллага даган мөрдсөнөөр бэлтгэсэн анхны санхүүгийн тайланд толилуулсан хамгийн эхний өмнөх тайлант үеийн эхэн юм.

- (б) Тогтоосон тэтгэмжийн үүргийн мэдрэмжит байдлын талаар 147-р параграфтаар шаардсан тодруулгад хамаарах зэрэгцүүлэгдэх мэдээллийг байгууллага нь 2018 оны 01 сарын 01-нээс өмнө эхэлсэн тайлант үеүдийн санхүүгийн тайланд толилуулах шаардлагагүй.

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

176. Байгууллага нь энэхүү Стандартыг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
177. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

### **УСНББОУС 25 (2008 он)-аас татгалзах ба орлуулах**

178. Энэхүү Стандарт нь УСНББОУС 25, *Ажилтны Тэтгэмж* (2008 он)-ийг орлоно. УСНББОУС 39-ийг мөрдөх эсвэл уг Стандарт хүчин төгөлдөр болох хугацааны аль түрүүнд болох өдөр хүртэл УСНББОУС 25 нь мөрдөгдсөн хэвээр байна.

**Хавсралт А****Мөрдөх заавар удирдамж**

*Энэ Хавсралт нь УСНББОУС 39-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

**19-р параграфыг үлгэрчлэн харуулах жишээ: Гүйцэтгэлд суурилсан шагналын хөтөлбөр**

МЗУ1. Гүйцэтгэлд суурилсан шагналын хөтөлбөрийн дагуу, Засгийн газрын хэвлэлийн нэгж нь урьдчилан тодорхойлсон гүйцэтгэлийн зорилтуудыг ханган биелүүлсэн ба тайлант жилийн туршид, өөрөөр хэлбэл тайлант үеийн эхнээс эцсийн өдөр хүртэл ажилласан ажилтнуудад тухайн жилийн ашгийн тодорхой хувийг олгох шаардлагатай. Хэрэв тайлант жилд нэг ч ажилтан ажлаасаа гарахгүй бол тухайн жилийн ашиг хуваалтын нийт төлбөр нь гүйцэтгэлийн ашгийн 3 хувьтай тэнцүү байна. Ажилтнууд ажлаас гарснаар энэхүү төлбөр нь ашгийн 2.5 хувь болтол буурна гэж уг байгууллага тооцоолсон.

Тухайн байгууллага нь ашгийн 2.5 хувиар өр төлбөр ба зардлыг хүлээн зөвшөөрнө.

**37-р параграфыг үлгэрчлэн харуулах жишээ: Олон ажил олгогчийн хөтөлбөрийн тайлагнал**

МЗУ2. Орон нутгийн засаг захиргааны А нэгж нь Х мужийн ижил төсөөтэй байгууллагуудын хамтаар олон ажил олгогчийн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрт оролцдог. Тус хөтөлбөр нь түүнд оролцож буй орон нутгийн засаг захиргааны бусад нэгжүүдийн одоогийн болон хуучин ажилтнуудтай холбоотой актуар эрсдлийг тэдгээр оролцогч байгууллагуудад хүлээлгэдэг учраас уг үүрэг, хөтөлбөрийн хөрөнгө, зардлыг тэрхүү хөтөлбөрт оролцогч орон нутгийн засаг захиргааны бие даасан нэгжүүдэд хуваарилах тууштай ба найдвартай суурь байхгүй. Иймээс орон нутгийн засаг захиргааны А нэгж нь уг хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөр байсан мэтээр тайлагнана. Энэ Стандартын шаардлагуудтай нийцсэн төсөөлөлд үндэслэн бэлтгээгүй санхүүжилтийн үнэлгээ нь уг хөтөлбөр 480 сая ТН<sup>(a)</sup>-ийн дутагдалтай байгааг харуулж байна. Заавал биелүүлэх хэлцлийн дагуу уг хөтөлбөр нь энэхүү дутагдлыг дараагийн таван жилийн хугацаанд арилгах шимтгэлийн хуваарийг хөтөлбөрт оролцогч ажил олгогч нартай тохиролцож гаргасан. Энэхүү гэрээний дагуу засаг захиргааны А нэгжийн оруулах нийт шимтгэлийн дүн нь 40 сая ТН байна.

Тус байгууллага нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн хувьд тохируулга хийсэн уг шимтгэлийн дүнгээр өр төлбөрийг, түүнчлэн холбогдох зардлыг түүнтэй тэнцүү дүнгээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

(a) Энэ Стандартад мөнгөн дүнг “тоолох нэгж (ТН)” гэж тэмдэглэсэн.

**70-р параграфыг үлгэрчлэн харуулах жишээ: Төсөвлөсөн нэгжийн кредит арга**

МЗУ3. Бөөн дүнгээр нэг удаа олгох тэтгэмж нь үйлчилгээг дуусгавар болгох (ажлаас гарах) үед төлөгдөх бөгөөд үйлчилгээ үзүүлсэн (ажилласан) жил бүрийн хувьд сүүлийн жилийн цалингийн 1 хувьтай тэнцүү байна. Эхний жилийн цалин нь 10,000ТН бөгөөд жил бүр цалинг 7 хувиар (нийлмэл хүү) нэмэгдүүлнэ гэж төсөөлж байгаа. Ашиглах дискаунтын түвшин нь жилд 10 хувь байна. 5 дахь жилийн эцэст ажлаас гарахаар хүлээгдэж буй ажилтны хувьд үүргийг хэрхэн хуримтлуулан тооцохыг дараах хүснэгтэнд харуулав. Энд актуар төсөөллүүдэд ямар нэг өөрчлөлт гарахгүй гэж үзсэн. Хялбарчлах үүднээс, ажилтан нь тухайн хугацаанаас өмнө эсвэл хожим уг байгууллагаас гарах магадлалыг тусгахын тулд хийх шаардлагатай нэмэлт тохируулгыг энэ жишээнд харгалзан үзээгүй болно.

<i>Жил</i>	<i>1</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>4</i>	<i>5</i>
<i>Хамаарах тэтгэмж:</i>					
<i>- өмнөх жилүүд</i>	<i>0</i>	<i>131</i>	<i>262</i>	<i>393</i>	<i>524</i>
<i>- тайлант жилд, (сүүлийн жилийн цалингийн 1%)</i>	<i>131</i>	<i>131</i>	<i>131</i>	<i>131</i>	<i>131</i>
<i>- тайлант ба өмнөх жилүүд</i>	<b><i>131</i></b>	<b><i>262</i></b>	<b><i>393</i></b>	<b><i>524</i></b>	<b><i>655</i></b>
<i>Жил</i>	<i>1</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>4</i>	<i>5</i>
<i>Үүргийн эхний үлдэгдэл</i>	<i>-</i>	<i>89</i>	<i>196</i>	<i>324</i>	<i>476</i>
<i>Хүү, 10 хувиар</i>	<i>-</i>	<i>9</i>	<i>20</i>	<i>33</i>	<i>48</i>
<i>Одоогийн үйлчилгээний зардал</i>	<i>89</i>	<i>98</i>	<i>108</i>	<i>119</i>	<i>131</i>
<i>Үүргийн эцсийн үлдэгдэл</i>	<b><i>89</i></b>	<b><i>196</i></b>	<b><i>324</i></b>	<b><i>476</i></b>	<b><i>655</i></b>

*Жич:*

- 1. Үүргийн эхний үлдэгдэл нь өмнөх жилүүдэд хамаарах тэтгэмжийн өнөөгийн үнэ цэнэ юм.*
- 2. Одоогийн үйлчилгээний зардал нь тайлант жилд хамаарах тэтгэмжийн өнөөгийн үнэ цэнэ юм.*
- 3. Үүргийн эцсийн үлдэгдэл нь тайлант болон өмнөх жилүүдэд хамаарах тэтгэмжийн өнөөгийн үнэ цэнэ юм.*

**73-р параграфыг үлгэрчлэн харуулах жишээ: Үйлчилгээ үзүүлсэн жилүүдэд тэтгэмжийг хамааруулан хуваарилах**

МЗУ4. Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр нь үйлчилгээ үзүүлсэн жил бүрийн хувьд 100ТН-ийн тэтгэмжийг тэтгэвэрт гарах үед бөөн дүнгээр олгох юм.

*100ТН-ийн тэтгэмжийг жил бүр хамааруулан хуваарилна. Одоогийн үйлчилгээний зардал нь уг 100ТН-ийн өнөөгийн үнэ цэнэ байдаг. Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ нь уг 100ТН-ийн өнөөгийн үнэ цэнийг тухайн тайлант үеийн эцэс хүртэл үйлчилгээ үзүүлсэн жилийн тоогоор үржүүлсэн дүн байна.*

*Хэрэв тэтгэмж нь тухайн байгууллагаас ажилтан гарах үед нэн даруй төлөгдөх өглөг бол одоогийн үйлчилгээний зардал ба тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ нь уг ажилтан ажлаас гарахаар хүлээгдэж буй хугацааг тусгадаг. Иймд дискаунтчлалын үр нөлөөний улмаас эдгээрийн дүн нь хэрэв ажилтан уг тайлант үеийн эцэст ажлаас гарсан бол тодорхойлогдох байсан дүнгээс бага байдаг.*

- МЗУ5. Хөтөлбөр нь сүүлийн жилийн цалингийн 0.2 хувиар сар бүр олгох тэтгэврийг үйлчилгээ үзүүлсэн жил бүрийн хувьд тооцож, бүрдүүлнэ. Тэтгэврийг 65-н наснаас эхэлж олгоно.

*Сүүлийн жилийн цалингийн 0.2 хувиар тооцож, тэтгэвэрт гарахаар хүлээгдэж буй өдрөөс эхлэн нас барах өдөр хүртэлх хугацаанд сар бүр олгох тэтгэврийн дүнгүүдийн уг тэтгэвэрт гарахаар хүлээгдэж буй өдрөөрх өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү байх тэтгэмжийг үйлчилгээ үзүүлсэн жил бүр хамааруулан хуваарилна. Одоогийн үйлчилгээний зардал нь уг тэтгэмжийн өнөөгийн үнэ цэнэ юм. Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ нь сүүлийн жилийн цалингийн 0.2 хувиар тооцож, сар бүр олгох тэтгэврийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг уг тайлант үеийн эцэс хүртэл үйлчилгээ үзүүлсэн жилийн тоогоор үржүүлсэн дүн байна. Тэтгэврийн төлбөр нь 65 наснаас эхэлдэг учраас одоогийн үйлчилгээний зардал ба тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийг дискаунтчилна.*

#### **74-р параграфыг үлгэрчлэн харуулах жишээ: Баталгаатай ба баталгаагүй тэтгэмж**

- МЗУ6. Хөтөлбөр нь үйлчилгээний жил бүрийн хувьд 100ТН-ийн тэтгэмж төлнө. 10-н жил үйлчилгээ үзүүлсний дараа тэтгэмж авах эрх баталгаатай болдог.

*100ТН-ийн тэтгэмжийг жил бүр хамааруулан хуваарилна. Эхний 10-н жил тус бүрийн хувьд одоогийн үйлчилгээний зардал ба үүргийн өнөөгийн үнэ цэнэ нь ажилтан 10-н жил үйлчилгээ үзүүлэхгүй байж болох магадлалыг тусгадаг.*

- МЗУ7. Хөтөлбөр нь үйлчилгээ үзүүлсэн жил бүрийн хувьд 100ТН-ийн тэтгэмж төлнө. Гэхдээ 25 нас хүрэхээс өмнө үзүүлсэн үйлчилгээ үүнд хамаарахгүй. Тэтгэмж авах эрх нь тэр даруй баталгаатай болдог.

*25 нас хүрэхээс өмнө үзүүлсэн үйлчилгээ нь (нөхцөлт буюу нөхцөлт бус) тэтгэмж авахад хүргэхгүй учраас 25 наснаас өмнөх үйлчилгээний хувьд тэтгэмжийг хамааруулан хуваарилахгүй. Дараагийн жил тус бүрд 100ТН-ийн тэтгэмжийг хамааруулан хуваарилна.*



**75-р параграфыг үлгэрчлэн харуулах жишээ: Тэтгэмжийг нягтлан бодох бүртгэлийн тайлант үеүдэд хамааруулан хуваарилах**

МЗУ8. Хөтөлбөр нь 1,000ТН-ийн тэтгэмжийг бөөн дүнгээр төлөх бөгөөд энэ нь арван жил үйлчилгээ үзүүлсний дараа баталгаатай болно. Харин дараагийн үеийн үйлчилгээний хувьд хөтөлбөр нь цаашид тэтгэмж олгохгүй.

*Эхний 10-н жил тус бүрд 100ТН-ийн (1,000ТН-ийг аравд хуваах) тэтгэмжийг хамааруулан хуваарилна. Эхний 10-н жил тус бүрийн одоогийн үйлчилгээний зардал нь тухайн ажилтан 10-н жил үйлчилгээ үзүүлэхгүй байж болох магадлалыг тусгадаг. Дараагийн жилүүдэд тэтгэмжийг хамааруулан хуваарилахгүй.*

МЗУ9. Хөтөлбөр нь 20-н жил үйлчилгээ үзүүлсэн ба одоо ч ажиллаж буй 55-н настай эсвэл үйлчилгээний хугацаанаас үл хамааран одоо ажиллаж буй 65-н настай бүх ажилтнууддаа тэтгэвэрт гарах үеийн 2,000ТН-ийн тэтгэмжийг нэг удаа бөөн дүнгээр төлдөг.

*35 наснаас өмнө ажиллаж эхэлсэн ажилтнуудын хувьд тэдний үйлчилгээ нь уг хөтөлбөрийн дагуу олгогдох тэтгэмжинд 35 наснаас эхэлж хамрагдахад хүргэдэг (ажилтан нь 30 настайдаа ажлаас гарч, 33 настайдаа буцаад ажилд орлоо гэхэд тэтгэмжийн дүн буюу хугацаанд нөлөө үзүүлэхгүй). Энэхүү тэтгэмж нь ирээдүйн үйлчилгээнээс нөхцөлт хамааралтай байна. Түүнчлэн, 55 наснаас хойш үзүүлсэн үйлчилгээ нь материаллаг дүн бүхий цаашдын тэтгэмжийг үүсгэхгүй. Байгууллага нь эдгээр ажилтнуудын хувьд 35 наснаас эхлэн 55 нас хүртэл жил бүр 100ТН-ийн (2,000ТН-ийг 20-д хуваах) тэтгэмжийг хамааруулан хуваарилна.*

*35-45 наснаасаа ажиллаж эхэлсэн ажилтнуудын хувьд 20 жилээс цаашхи хугацааны үйлчилгээ нь материаллаг дүн бүхий цаашдын тэтгэмжийг үүсгэхгүй. Эдгээр ажилтнуудын хувьд байгууллага нь эхний хорин жил тус бүр 100ТН-ийн (2,000ТН-ийг 20-д хуваах) тэтгэмжийг хамааруулан хуваарилна.*

*55 наснаасаа ажиллаж эхэлсэн ажилтны хувьд 10 жилээс цаашхи хугацааны үйлчилгээ нь материаллаг дүн бүхий цаашдын тэтгэмжийг үүсгэхгүй. Энэ ажилтны хувьд байгууллага нь эхний арван жил тус бүр 200ТН-ийн (2,000ТН-ийг 10-д хуваах) тэтгэмжийг хамааруулан хуваарилна.*

*Бүх ажилтнуудын хувьд одоогийн үйлчилгээний зардал ба үүргийн өнөөгийн үнэ цэнэ нь ажилтан үйлчилгээний шаардлагатай хугацааг ханган биелүүлэхгүй байж болох магадлалыг тусгадаг.*

МЗУ10. Ажил эрхлэлтийн дараах эмнэлгийн хөтөлбөр нь ажилтан арван жилээс илүү боловч хорин жилээс бага хугацаанд үйлчилгээ үзүүлсний дараа ажлаас гарсан бол уг ажилтны ажил эрхлэлтийн дараах эмнэлгийн

зардлын 40 хувийг, харин хорь буюу түүнээс олон жил үйлчилгээ үзүүлсний дараа ажлаас гарсан бол эмнэлгийн зардлын 50 хувийг нөхөн олгодог.

*Энэхүү хөтөлбөрийн тэтгэмжийн томъёоны дагуу байгууллага нь хүлээгдэж буй эмнэлгийн зардлын өнөөгийн үнэ цэнийн 4 хувийг (40 хувийг аравд хуваах) эхний арван жил тус бүрд, харин 1 хувийг (10 хувийг аравд хуваах) дараагийн арван жил тус бүрд хамааруулан хуваарилна. Жил бүрийн одоогийн үйлчилгээний зардал нь тухайн тэтгэмжийн бүх буюу зарим хэсгийг олж авахад шаардлагатай үйлчилгээний хугацааг ажилтан ханган биелүүлэхгүй байж болох магадлалыг тусгадаг. Арван жилийн дотор ажлаас гарахаар хүлээгдэж буй ажилтнуудын хувьд ямар нэг тэтгэмж хуваарилан тооцохгүй.*

МЗУ11. Ажил эрхлэлтийн дараах эмнэлгийн хөтөлбөр нь ажилтан арван жилээс илүү боловч хорин жилээс бага хугацаанд үйлчилгээ үзүүлсний дараа ажлаас гарсан бол уг ажилтны ажил эрхлэлтийн дараах эмнэлгийн зардлын 10 хувийг, харин хорь буюу түүнээс олон жил үйлчилгээ үзүүлсний дараа ажлаас гарсан бол эмнэлгийн зардлын 50 хувийг нөхөн олгодог.

*Сүүлийн жилүүд дэх үйлчилгээ нь эхний жилүүд дэх үйлчилгээнээс материаллагаар өндөр түвшний тэтгэмж бий болгоно. Иймээс хорь буюу түүнээс олон жилийн дараа ажлаас гарахаар хүлээгдэж буй ажилтнуудын хувьд байгууллага нь 73-р параграфын дагуу тэтгэмжийг шулуун шугамын сууриар шингээн хуваарилна. 20 жилээс цааших хугацааны үйлчилгээ нь материаллаг дүн бүхий цаашдын тэтгэмжийг үүсгэхгүй. Иймээс эхний хорин жил тус бүрд хамааруулан хуваарилах тэтгэмж нь хүлээгдэж буй эмнэлгийн зардлын өнөөгийн үнэ цэнийн 2.5 хувь (50 хувийг хорьд хуваах) байна.*

*Арваас хорин жилийн хооронд ажилласны дараа ажлаас гарахаар хүлээгдэж буй ажилтнуудын хувьд эхний арван жил тус бүрд хамааруулан хуваарилах тэтгэмж нь хүлээгдэж буй эмнэлгийн зардлын өнөөгийн үнэ цэнийн 1 хувьтай тэнцүү байна. Эдгээр ажилтнуудын хувьд арав дахь жилийн эцэс ба ажлаас гарах тооцоолсон хугацааны хооронд үзүүлсэн үйлчилгээнд ямар нэг тэтгэмж хамааруулан хуваарилахгүй.*

*Арван жилийн дотор ажлаас гарахаар хүлээгдэж буй ажилтнуудын хувьд ямар нэг тэтгэмж хамааруулан хуваарилахгүй.*

## **76-р параграфыг үлгэрчлэн харуулах жишээ: Тэтгэмжийг нягтлан бодох бүртгэлийн тайлант үеүдэд хамааруулан хуваарилах**


МЗУ12. 55 наснаас өмнөх үйлчилгээ үзүүлсэн жил тус бүрийн хувьд сүүлийн жилийн цалингийн 3 хувиар тооцож, тэтгэмж авах эрхийг ажилтнуудад олгодог.

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

Сүүлийн жилийн цалингийн 3 хувиар тооцох тэтгэмжийг 55 нас хүртэлх жил тус бүрд хамааруулан хуваарилна. Энэ нь ажилтны цаашдын үзүүлэх үйлчилгээгээр уг хөтөлбөрийн дагуу олгогдох материаллаг дүн бүхий тэтгэмжийг цаашид үүсгэхгүй болох өдөр юм. Энэхүү наснаас хойш үзүүлсэн үйлчилгээний хувьд тэтгэмжийг хамааруулан хуваарилахгүй.

### 94 ба 95-р параграфыг үлгэрчлэн харуулах жишээ: Ажилтнууд буюу гуравдагч талаас оруулах шимтгэл

МЗУ13. Ажилтнууд буюу гуравдагч талаас оруулах шимтгэлийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг дараах схемд үлгэрчлэн харуулав.



(1) Энэхүү тасархай шугам нь нягтлан бодох бүртгэлийн аль нэг хувилбарыг тухайн байгууллага сонгохыг зөвшөөрнө гэсэн утгыг илэрхийлнэ.

**162-173-р параграфыг үлгэрчлэн харуулах жишээ: Ажлаас халагдалтын тэтгэмж**

МЗУ14. Танилцуулга

Саяхан хийсэн бизнесийн худалдан авалтын үр дүнд байгууллага нь нэг үйлдвэрийг арван сарын дотор хааж, уг үйлдвэрийн үлдэх бүх ажилтнуудын ажил эрхлэлтийг дуусгавар болгохоор төлөвлөж байна. Зарим гэрээт ажлыг хэрэгжүүлж дуусгахад уг үйлдвэрийн ажилтнуудын мэргэшил, мэдлэг шаардлагатай тул байгууллага нь ажлаас халах арга хэмжээгээ дараах байдлаар танилцуулсан.

Үйлдвэрийг хаах хүртэл ажиллаж, үйлчилгээгээ үзүүлсэн ажилтан бүр нь 30,000ТН-ийн мөнгөн төлбөрийг ажлаас халагдах өдрөө авна. Харин үйлдвэрийг хаахаас өмнө ажлаас гарсан ажилтнууд нь 10,000ТН-ийн мөнгөн төлбөр авна.

Энэ үйлдвэрт одоогоор 120 ажилтан байгаа. Байгууллага нь уг арга хэмжээг танилцуулах үедээ 20 ажилтан үйлдвэрийг хаахаас өмнө ажлаас гарна гэж төлөвлөж байсан. Иймээс уг арга хэмжээний дагуу зарцуулахаар хүлээгдэж буй нийт мөнгөн зарлага нь 3,200,000ТН (тодруулбал; 20x10,000ТН+100x30,000ТН) байна. 163-р параграфтаар шаардсаны дагуу, байгууллага нь ажил эрхлэлтийг дуусгавар болгосны хариуд олгох тэтгэмжийг ажлаас халагдалтын тэтгэмж байдлаар, харин үзүүлсэн үйлчилгээний хариуд олгох тэтгэмжийг ажилтны богино хугацааны тэтгэмж байдлаар тайлагнана.

*Ажлаас халагдалтын тэтгэмж*

Ажил эрхлэлтийг дуусгавар болгосны хариуд олгох тэтгэмж нь 10,000ТН байна. Энэ нь ажилтан үйлдвэрийг хаах хүртэл байж, үйлчилгээгээ үзүүлэх эсвэл үйлдвэрийг хаахаас өмнө ажлаас гарах эсэхээс үл хамааран ажил эрхлэлтийг дуусгавар болгосны хариуд тухайн байгууллагын төлөх ёстой дүн юм. Хэдийгээр ажилтнууд нь үйлдвэрийг хаахаас өмнө ажлаасаа гарч болох боловч бүх ажилтнуудын ажил эрхлэлтийн дуусгавар болголт нь үйлдвэрийг хаах ба ажил эрхлэлтийг дуусгавар болгох тухайн байгууллагын шийдвэрийн үр дүн байна (өөрөөр хэлбэл, үйлдвэрийг хаах үед бүх ажилтан ажлаас гарна). Иймээс уг ажлаас халах арга хэмжээг зарлан мэдэгдсэн өдөр ба үйлдвэрийг хаахтай холбоотой бүтцийн өөрчлөлтийн зардлыг тухайн байгууллага хүлээн зөвшөөрсөн өдрийн аль түрүүнд болох өдрөөр байгууллага нь ажилтны тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу олгох ажлаас халагдалтын тэтгэмжийн хувьд 1,200,000ТН-ийн (тодруулбал; 120x10,000ТН) өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

*Үзүүлсэн үйлчилгээний хариуд олгох тэтгэмж*

Ажилтан бүтэн арван сарын хугацаанд үйлчилгээгээ үзүүлснээр түүний авах нэмэлт тэтгэмж нь тухайн хугацааны туршид үзүүлсэн үйлчилгээний

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

хариуд олгох тэтгэмж болох юм. Байгууллага нь уг тэтгэмжийг тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор барагдуулахаар хүлээж буй учраас ажилтны богино хугацааны тэтгэмж байдлаар тайлагнана. Энэ жишээний хувьд дискаунтчлах шаардлагагүй учраас үйлчилгээ үзүүлэх арван сарын хугацааны туршид сар бүр 200,000ТН-ийн (тодруулбал, 2,000,000ТН/10) зардлыг хүлээн зөвшөөрөх ба өр төлбөрийн дансны үнийг харгалзан нэмэгдүүлнэ.

## Хавсралт Б

### Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 39-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Зорилго

- ДҮ1. УСНББОУС 25 (2008 он), *Ажилтны Тэтгэмж*-ийг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 19 (2004 он), *Ажилтны Тэтгэмж*-ээс үндсэндээ бэлтгэсэн болно. 2011-2015 оны хооронд НББОУСЗ нь НББОУС 19-д олон тооны нэмэлт өөрчлөлтийг оруулсан.
- ДҮ2. УСНББОУС 25-ыг шинэчлэн баяжуулахдаа УСНББОУСЗ нь уг хянан засварласан НББОУС 19-тэй нийцүүлэх үүднээс УСНББОУС 25-ыг хязгаарлагдмал хүрээнд хянах ажлыг зөвшөөрөн баталсан. УСНББОУСЗ нь Нийгмийн Хамгааллын Холимог Хөтөлбөрт (доорх ДҮ5, ДҮ6-р параграфуудыг үзнэ үү) хамаарах хэсгүүдээс бусад, УСНББОУС 25 дахь улсын секторын тусгай шаардлагуудыг дахин авч үзэхгүй байхаар шийдвэрлэсэн.
- ДҮ3. 2016 оны 01 дүгээр сард УСНББОУСЗ нь Саналын Төсөл (СТ) 59, *УСНББОУС 25, Ажилтны Тэтгэмж-д оруулах Нэмэлт өөрчлөлт*-ийг гаргасан. НББОУС 19-тэй нийцтэй байдлыг хадгалахын тулд хийвэл зохих нэмэлт өөрчлөлтүүдийг СТ 59-д санал болгосон. Уг санал болгосон нэмэлт өөрчлөлтөөр УСНББОУС 25-ын үндсэн текстэд маш олон тооны өөрчлөлт оруулсан. Хариулт ирүүлсэн олон хүмүүс нь ийм олон өөрчлөлтүүдийн үр дүнд УСНББОУС 25-ын ойлгомжтой байдал алдагдана гэдгийг илэрхийлсэн. Иймээс УСНББОУСЗ нь санхүүгийн тайлан бэлтгэгч нарт туслах үүднээс уг хянан засварласан УСНББОУС 25-ыг биш, харин шинэ УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг гаргахаар шийдвэрлэсэн.
- ДҮ4. УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн дүгнэлтүүдэд хүрэхдээ УСНББОУСЗ-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. Нийгмийн Хамгааллын Холимог Хөтөлбөрөөс бусад зүйлсийн хувьд УСНББОУС 39 нь НББОУС 19 (2011 он болон түүнээс хойш нэмэлт өөрчлөлт оруулсан)-ийн гол шаардлагуудаас гажсан эсвэл УСНББОУСЗ нь ийм гажилтыг авч үзсэн зөвхөн тэдгээр талбаруудыг Дүгнэлтийн Үндэслэлд хамруулсан.

### *Нийгмийн Хамгааллын Холимог Хөтөлбөр*

- ДҮ5. Нийгмийн Хамгааллын Холимог Хөтөлбөрийг аль нэг улс оронд мөрддөг эсэх талаар УСНББОУСЗ нь мэдээлэлгүй байсан учраас энэ хэсгийг хасах эсэхийг авч үзсэн талаар СТ 59-д дурдсан. Энэ асуудлын талаар санал ирүүлэхийг УСНББОУСЗ нь тусгайлан хүссэн.

ДҮ6. СТ 59-д хариулт ирүүлсэн хүмүүс нь эдгээр шаардлагыг дагаж мөрддөг байгууллагууд бүхий улс орныг тогтоогоогүй. Хариулт ирүүлсэн ихэнх хүмүүс нь Нийгмийн Хамгааллын Холимог Хөтөлбөрийн талаархи уг хэсгийг хасахыг дэмжсэн. УСНББОУСЗ нь энэ хэсгийг хэвээр үлдээх шинэ буюу зайлшгүй учир шалтгааныг тогтоогоогүй тул үүнийг УСНББОУС 39-д оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.

Улсын хөтөлбөр

ДҮ7. Байгууллага нь олон ажил олгогчийн хөтөлбөрийг тайлагнадагтай ижил арга замаар улсын хөтөлбөрийг тайлагнах НББОУС 19-ийн шаардлагыг энэ Стандартад хэвээр үлдээсэн. Улсын секторын байгууллагууд нь улсын хөтөлбөрийг тайлагнах арга хандлагаа УСНББОУС 25-д тусгасантай адилаар тодорхой болгох цаашдын тайлбарыг оруулах хэрэгтэй гэж УСНББОУСЗ үзсэн. Улсын хөтөлбөр нь хяналт тавигч байгууллагын тогтоосон тэтгэмжийн хөтөлбөртэй адил шинж чанартай байна гэсэн няцааж болох урьдчилсан нөхцлийг 47-р параграфт заасан байдаг. Энэхүү урьдчилсан нөхцөл зөвхөн няцаагдсан тохиолдолд улсын хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөр байдлаар тайлагнана.

*Ерөнхий хяналтанд буй оролцогч байгууллагууд бүхий тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр*

ДҮ8. Ерөнхий хяналтанд буй байгууллагууд нь тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрт оролцох олон тохиолдол улсын секторт гарах магадлалтай байдаг. НББОУС 19 нь ерөнхий хяналтанд буй байгууллагуудын хооронд эрсдлийг хуваах тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн талаархи тайлбарыг тусгасан байдаг. НББОУС 19-ийн шаардлагууд нь улсын секторын хувьд тохиромжтой гэж УСНББОУСЗ үзсэн. Тухайн хөтөлбөрийн тогтоосон тэтгэмжийн цэвэр зардлыг бүхэлд нь, уг бие даасан байгууллагад шингээн хуваарилах гэрээний тохиролцоо, заавал биелүүлэх хэлцэл эсвэл тогтсон бодлого байхаас бусад тохиолдолд хяналтанд буй байгууллагууд нь УСНББОУС 25-д заасантай адилаар тогтоосон тэтгэмжид үндэслэн тайлагнах нь тохиромжгүй гэдгийг УСНББОУСЗ нь мөн онцлон тэмдэглэх хэрэгтэй гэж үзсэн. Ийм тохиолдолд хяналт тавигч байгууллага нь уг хөтөлбөрийг тогтоосон тэтгэмжид үндэслэн өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тайлагнана. Хяналтанд буй байгууллагууд нь (а) тогтоосон шимтгэлд үндэслэн тайлагнана, (б) тухайн хяналт тавигч байгууллагыг тодорхойлно, (в) хяналт тавигч байгууллага нь тогтоосон тэтгэмжид үндэслэн өөрийн ын нэгтгэсэн санхүүгийн тайланд тайлагнадаг гэдгийг тодруулна. Энэ талаар 42-р параграфт заасан. Хяналтанд буй байгууллагууд нь 151-р параграфт тусгайлан заасан тодруулгыг бас хийнэ.

*Дискаунтын түвшин*

ДҮ9. Тухайн тайлант үеийн эцэс дэх корпорацийн өндөр чанартай бондын зах зээлийн өгөөжид үндэслэн дискаунтын түвшинг тодорхойлохыг НББОУС 19-өөр шаардсан байдаг. Дискаунтын түвшин нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусгасан байвал зохино гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн бөгөөд



УСНББОУС 25-д заасантай адил арга замаар уг зорилтыг хамгийн сайнаар хангах тийм дискаунтын түвшинг тодорхойлох боломжийг байгууллагуудад олгох хэрэгтэй эсэхийг харгалзан үзсэн. Засгийн газрын бонд, корпорацийн өндөр чанартай бонд буюу бусад аливаа санхүүгийн хэрэглүүрийн зах зээлийн өгөөжийг лавлагаа болгосноор мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг хамгийн сайнаар тусгаж болно гэж УСНББОУСЗ үзсэн. Ашигласан дискаунтын түвшин нь тогтоосон тэтгэмжийн үүрэгтэй холбоотой эрсдэл эсвэл байгууллагын тусгайлсан зээлийн эрсдлийг тусган илэрхийлэх санаа зорилгогүй байдаг. Дискаунтын түвшинг тодорхойлсон суурь үндэслэлийн талаар хэрэглэгчдэд мэдээлэх тодруулгын нэмэлт шаардлагыг 141(г) параграфт заасан.

ДҮ10. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусган илэрхийлэх дискаунтын түвшинг тодорхойлох засгийн газрын бондын болон корпорацийн өндөр чанартай бондын аль алины өргөн зах зээл байхгүй улс орнуудад үйл ажиллагаагаа явуулж буй байгууллагуудад туслах заавар удирдамжаар хангах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Тохиромжтой дискаунтын түвшний тодорхойлолт нь ийм улс оронд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хувьд төвөгтэй асуудал байх магадлалтай бөгөөд тэдгээр байгууллагууд нь аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлд шилжиж байгаа буюу саяхан шилжсэн байж болох юм гэж УСНББОУСЗ мэдэгдсэн. Гэвч энэ нь зөвхөн улсын секторт хамаарах асуудал биш бөгөөд ийм заавар удирдамжаар хангахгүй байх улсын секторын тусгайлсан тодорхой шалтгаан үндэслэл байхгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

*Ажилтны урт хугацааны бусад тэтгэмж: Удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж*

ДҮ11. Удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг НББОУС 19-д “Ажилтны урт хугацааны бусад тэтгэмж”-ийн жишээ болгон харуулсан байдаг. “Ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хэмжилт нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хэмжилттэй адил тийм их тодорхой бус байдалд ихэвчлэн хамаардаггүй” гэж НББОУС 19-д заасан. Цэргийн алба гэх мэт улсын сектор дахь үйлчилгээний тодорхой талбартай холбоотой хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж нь санхүүгийн хувьд мэдэгдэхүйц дүнтэй бөгөөд холбогдох актуар олз, гарз нь ихээхэн хувьсан өөрчлөгддөг.

ДҮ12. Иймээс удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хэмжилттэй адил тийм их тодорхой бус байдалд ихэвчлэн хамаардаггүй гэсэн УСНББОУС 25-ын няцааж болох урьдчилсан нөхцлийг УСНББОУС 39-д тэр хэвээр хадгалж үлдээсэн. Энэхүү урьдчилсан нөхцөл няцаагдсан тохиолдолд уг байгууллага нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжид хамаардагтай ижил шаардлагуудыг ашигласнаар удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны бүх буюу зарим төлбөрийг тайлагнах хэрэгтэй эсэхийг харгалзан үзнэ.

*Ажилтны урт хугацааны бусад тэтгэмж: Тухайн хувь хүн нь шинэ ажилд орох хүртэл уг тайлагнагч байгууллагаас олгох нөхөн төлбөрийн өглөг*

ДҮ13. Ийм нөхцөл байдал түгээмэл байх магадлалтай гэж үздэггүй боловч тайлагнагч байгууллага нь ажлаас халагдалтын тэтгэмжээс гадна уг хуучин ажилтнаа өөр шинэ ажилд орох хүртэл нөхөн төлбөр олгох гэрээний үүрэг хүлээх тийм тохиолдол гарч болно гэж УСНББОУСЗ мэдэгдсэн. Иймээс УСНББОУС 25-д заасан, ийм нөхцөл байдлуудыг тусган оруулахын тулд 155-р параграф дахь ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн жагсаалтанд нэмэлт өөрчлөлт оруулсан.

#### *Дахин хэмжилт*

ДҮ14. НББОУС 19 (2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-д зааснаар, тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилтийн дүнг ашиг, алдагдалд биш, харин бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал-д “бусад дэлгэрэнгүй орлого”-ыг дурдаагүй бөгөөд УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Топилуулга-д “бусад дэлгэрэнгүй орлого”-ын тодорхойлолтыг оруулаагүй гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн.* Дахин хэмжилтийн дүнг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх нь НББОУС 19-тэй ижил нягтлан бодох бүртгэлийн үр дагавартай бөгөөд урьдчилан таамагласан янз бүрийн үнэ цэнэ бүхий тогтоосон тэтгэмжийн зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд ашиг, алдагдалд нөлөөлөхгүй гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс УСНББОУСЗ нь дахин хэмжилтийн дүнг ашиг, алдагдалд биш, харин цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөхөөр шийдвэрлэсэн.

ДҮ15. Байгууллага нь ижил төсөөтэй зүйлсийн материаллаг анги нэг бүрийг санхүүгийн тайландаа тусад нь толилуулахыг УСНББОУС 1-ийн 45-р параграфтаар шаардсан гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Ижил төсөөгүй шинж төрөл буюу чиг үүрэг бүхий зүйлс нь материаллаг бус байхаас бусад тохиолдолд тэдгээрийг тусад нь толилуулдаг. Иймээс ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн дахин хэмжилтийн дүн нь хэрэв материаллаг бол цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тусад нь толилуулах шаардлагатай байж болно гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн.

#### *Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн Тайлагналын Зааврын шаардлагууд*

ДҮ16. УСНББОУСЗ нь ажилтны тэтгэмжийн ангилал, толилуулга, хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тодруулгын талаархи Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС)-ийн тайлагналын зааврын шаардлагуудыг харгалзан үзсэн бөгөөд уг хянан засварласан НББОУС 19 ба УСНББОУС 39-ийн аль алианаас зөрүүтэй зарим шаардлагуудыг олж тогтоосон.

ДҮ17. ЗГСС-ийн тайлагналын зааврыг цэвэр хүүний арга хандлагад мөрддөггүй боловч сангийн хөрөнгийн орлого, сангийн өр төлбөрийн хүүг эдгээр орлого, зардлын эдийн засгийн шинж төрлийн дагуу хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн, ЗГСС нь үл хөдлөх хөрөнгө (өмч)-өөс үүссэн орлого ба цаг

## АЖИЛТНЫ ТЭТГЭМЖ

хугацаа урсан өнгөрснөөр нөхөн төлбөр төлөх үүргийн өсөлтийг “Хөрөнгө оруулалтын орлогын төлбөрт хамаарах үл хөдлөх хөрөнгө (өмч)-ийн зардал” гэсэн зүйлд бичилт хийснээр хүлээн зөвшөөрдөг. Үүнтэй адилтгах бичилтийг УСНББОУС 39-д зааснаар ашиг, алдагдалд тусгадаг.

- ДҮ18. Ажил олгогчийн данс тооцооноос гадуур хүлээн зөвшөөрдөг бие даасан сангийн хувьд ЗГСС нь тодорхой нөхцөлд үүссэн тэтгэврийн сангийн дутагдалд хамаарах тэтгэврийн сангийн нэхэмжлэлийг уг тэтгэврийн сангийн менежерээс авах байдлаар хүлээн зөвшөөрдөг. Ийм тохиолдолд ЗГСС нь уг нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсний үр дүнд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр үүсэх хүүний зардлыг тухайн ажил олгогчийн данс тооцоонд тусгахыг шаарддаггүй.
- ДҮ19. ЗГСС-т хөтөлбөрийн хөрөнгийг ерөнхийдөө бусад хөрөнгийг хэмжсэнтэй адил сууриар буюу хэвийн зах зээлийн үнэ цэнээр хэмждэг. Иймээс УСНББОУС 39-өөс ялгаатай нь, дискаунтын түвшинг бүхэлд нь тухайн хөтөлбөрийн хөрөнгөнд тусган оруулж, өнөөгийн үнэ цэнийг тооцоолох нэмэлт тооцоолол хийх шаардлагагүй байдаг. Гэхдээ ЗГСС-т зарим хөрөнгийг зах зээлийн үнэ цэнээр хэмждэггүй. Энэ нь УСНББОУС 39 ба ЗГСС-ийн хооронд ялгаатай үнэлгээ (жишээлбэл; зээлийг ЗГСС-т нэрлэсэн үнээр хэмждэг бол УСНББОУС-д ихэвчлэн хорогдуулсан өртгөөр хэмждэг) хийхэд хүргэдэг.
- ДҮ20. ЗГСС-ийн хувьд, ажил гүйлгээнээс үүсээгүй хөрөнгийн тоо хэмжээний болон үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг Эдийн Засгийн Бусад Гүйлгээний тайланд бүртгэдэг бөгөөд цаг хугацаа урсан өнгөрөлтийн үр нөлөөг үүнд тусган оруулдаг. ЗГСС-ийн хувьд тэтгэврийн сан нь хүү, ногдол ашиг, түрээс гэх мэт ажил гүйлгээний бодит орлогыг Үйл Ажиллагааны Тайланд бүртгэдэг.
- ДҮ21. ЗГСС нь ажилтны тэтгэмжийг богино хугацааны ба урт хугацааны тэтгэмж гэж салган заагладаггүй бөгөөд Үндэсний Тооцооны Систем 2008-д тусгайлан заасан нийгмийн даатгалын тэтгэврийн схемийн нэмэлт хүснэгтээс бусад, ажилтны тэтгэмжийн талаархи тусгай тодруулга хийхийг шаарддаггүй.
- ДҮ22. Эдгээр зөрүүтэй байдал нь УСНББОУС-ын болон ЗГСС-ийн ялгаатай зорилго ба толилуулгын үзэл баримтлалаас хамаардаг гэж УСНББОУС3 дүгнэсэн. Эдгээр нь НББОУС 19-өөс гажихыг зөвтгөн батлах улсын секторын тусгай учир шалтгаан болохгүй юм.

## НББОУС 19-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 19-ийг НББОУС 19 (2011 онд гаргасан, үүн дотроо 2015 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан)-өөс үндсэндээ бэлтгэсэн болно. УСНББОУС 39 ба НББОУС 19-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 39 нь улсын секторын шагналын хөтөлбөрийн талаархи нэмэлт заавар удирдамжийг агуулсан байдаг.
- Ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн үүргийн дискаунтчлалын хувьд, аж ахуйн нэгжүүд нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн үүргийн валют болон тооцоолсон хугацаатай нийцэх, корпорацийн өндөр чанартай бондын өгөөжид үндэслэсэн дискаунтын түвшин ашиглахыг НББОУС 19-өөр шаарддаг. УСНББОУС 39-ийн шаардлагын дагуу байгууллагууд нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тусгасан дискаунтын түвшин ашиглана. УСНББОУС 39 нь дискаунтын түвшинг тодорхойлсон сууриа байгууллагууд тодруулах талаархи шаардлагыг бас агуулсан байдаг.
- Удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийн төлбөр нь ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хэмжилттэй адил тийм тодорхойгүй байдлын зэрэг хэмжээтэй байдаггүй гэсэн няцааж болох урьдчилсан нөхцлийг УСНББОУС 39-д тусгасан байдаг. Энэхүү урьдчилсан нөхцөл няцаагдсан тохиолдолд уг байгууллага нь удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсаны бүх буюу зарим төлбөрийг ажил эрхлэлтийн дараах тэтгэмжтэй адилаар тайлагнах хэрэгтэй эсэхийг харгалзан үздэг.
- УСНББОУС 39-д заасны дагуу, тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилтийн дүнг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг. Харин НББОУС 19-ийн дагуу эдгээрийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрдөг.
- УСНББОУС 39 нь зарим тохиолдолд НББОУС 19-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь “орлого” /revenue/, “хяналт тавигч байгууллага”, “хяналтанд буй байгууллага” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 19 дэх адилтгах нэр томъёо нь “орлого” /income/, “толгой компани”, “охин компани” юм.

## УСНББОУС 40–УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ын худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) 3, *Бизнесийн Нэгдэл*-ээс бэлтгэсэн болно. СТОУС 3-аас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## **УСНББОУС 40-УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ**

### **УСНББОУС-ЫН ТҮҮХ**

*Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.*

УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийг 2017 оны 01 дүгээр сард гаргасан.

## УСНББОУС 40–УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

## АГУУЛГА

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-4
Тодорхойлолт	5
Улсын секторын нэгдлийг тодорхойлох	6
Улсын секторын нэгдлийн ангилал	7-14
Нэгдэл нь нийлүүлэлт гэсэн нотолгоогоор хангаж болох үзүүлэлтүүд	12-14
Нийлүүлэлтийн тайлагнал	15
Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга	16-57
Үр дүнгийн байгууллагыг тогтоох	17-18
Нийлүүлэх өдрийг тодорхойлох	19-20
Тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон нэгдэгч үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба хэмжих	21-35
Нийлүүлэлтийн үр дүнд үүссэн цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих	36-39
Хэмжилтийн хугацаа	40-44
Нийлүүлэлттэй холбоотой зардал	45
Дараагийн тайлант үеийн хэмжилт ба нягтлан бодох бүртгэл	46-49
Санхүүгийн тайлангийн толилуулга	50-52
Тодруулга	53-57
Худалдан авалтын тайлагнал	58
Худалдан авалтын тайлагналын арга	59-125
Нэгтгэгчийг тодорхойлох	60-61
Худалдан авалтын өдрийг тодорхойлох	62-63
Олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба хэмжих	64-84
Тохиролцоот худалдан авалтаас үүсэх гүүдвил буюу олзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих	85-98
Үе шаттайгаар хийсэн худалдан авалт	99-100
Саналын эрхийн өөрчлөлтөөр, зөвхөн гэрээгээр болон төлбөр шилжүүлэхгүйгээр үүнтэй адилтгах нөхцөлд худалдан авалтыг хийсэн тохиолдолд худалдан авалтын аргыг хэрэглэх талаархи нэмэлт заавар удирдамж	101-102
Хэмжилтийн хугацаа	103-108
Худалдан авалтын ажил гүйлгээний нэг хэсэг болох эсэхийг тодорхойлох	109-111
Дараагийн тайлант үеийн хэмжилт ба нягтлан бодох бүртгэл	112-118

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

Тодруулга	119-125
Хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилт	126-134
Хүчин төгөлдөр болох хугацаа	126
Шилжилт	127-134
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
Үлгэрчилсэн жишээ	
СТОУС 3-тай харьцуулалт	



## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийг 1-62-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 40-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэхүү Стандартын зорилго нь улсын секторын нэгдэл болон түүний үр нөлөөний талаар тайлагнагч байгууллага өөрийн санхүүгийн тайландаа тусгасан мэдээллийн хамааралтай, үнэн зөв толилуулга болон зэрэгцүүлэгдэх байдлыг сайжруулахад оршино. Уг зорилгыг хангахын тулд дараах зүйлсийг хэрхэн гүйцэтгэх талаархи зарчим ба шаардлагыг энэ Стандартад тогтоосон:
  - (а) Тайлагнагч байгууллага нь улсын секторын нэгдлийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах;
  - (б) Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтийн үр дүнд олж авсан тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон аливаа хяналтын бус хувь оролцоог өөрийн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрч, хэмжих;
  - (в) Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтээр хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүд болон бусад тохируулгыг хүлээн зөвшөөрч, хэмжих;
  - (г) Нэгтгэгч нь олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог өөрийн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрч, хэмжих;
  - (д) Нэгтгэгч нь худалдан авалтаар олж эзэмшсэн гүүдвил буюу үүссэн олз, гарзыг хүлээн зөвшөөрч, хэмжих;
  - (е) Тайлагнагч байгууллага нь улсын секторын нэгдлийн шинж төрөл ба санхүүгийн үр нөлөөг үнэлэх боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгохын тулд тодруулга хийх мэдээллийг тодорхойлох.

## Цар хүрээ

2. Нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь улсын секторын нэгдлийг тайлагнахдаа энэхүү Стандартыг мөрдөнө.
3. Улсын секторын нэгдлийн тодорхойлолтыг хангаж буй ажил гүйлгээ болон бусад үйл явдалд энэхүү Стандартыг мөрдөнө. Харин энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөхгүй:
  - (а) Байгуулсан хамтын хэлэлцээрийг тухайн хамтын хэлэлцээрийн өөрийнх нь санхүүгийн тайланд тайлагнах.
  - (б) Үйл ажиллагааг үүсгэн бүрдүүлэхгүй хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийг (болон холбогдох өр төлбөрийг) худалдан авах буюу хүлээн авах. Энэ тохиолдолд байгууллага нь худалдан авсан буюу хүлээн авсан тухайн бие даасан тодорхойлогдох хөрөнгүүд (үүн дотроо, УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-нд заасан биет бус хөрөнгийн тодорхойлолт болон

хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангадаг хөрөнгүүд) ба хариуцах өр төлбөрүүдийг тогтоож, хүлээн зөвшөөрнө. Ийм ажил гүйлгээ буюу үйл явдал нь гүүдвил үүсэхэд хүргэхгүй.

- (в) Үйл ажиллагааг үүсгэн бүрдүүлэхгүй өр төлбөр буюу өр төлбөрүүдийн бүлгийг хариуцах. Энэ тохиолдолд байгууллага нь хариуцсан тухайн бие даасан өр төлбөрүүдийг тогтоож, хүлээн зөвшөөрнө.

4. УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-д тодорхойлсончлон, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг, хөрөнгө оруулалтын байгууллагын хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтын худалдан авалтын хувьд энэ Стандартын шаардлагуудыг мөрдөхгүй.

## Тодорхойлолт

5. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Улсын секторын нэгдэл гэдэг нь тусдаа үйл ажиллагаануудыг улсын секторын нэг байгууллагад нэгтгэн оруулахыг хэлнэ.

## Улсын секторын бүх нэгдэлтэй холбоотой ерөнхий тодорхойлолтууд

Энэ Стандартын зорилгын хувьд, хөрөнгө оруулагчийн өмчилдөг байгууллагуудын өмчлөлийн хувь оролцоо болон хамтын байгууллагын эзэн, гишүүн буюу оролцогчийн хувь оролцоог илэрхийлэхийн тулд өмчийн хувь оролцоог өргөн утгатайгаар ашигладаг.

Дараах аль нэг тохиолдолд хөрөнгө нь тодорхойлогдох боломжтой байна:

- (а) Салган тусгаарлаж болох, өөрөөр хэлбэл байгууллага нь ингэх санаа бодолтой эсэхээс үл хамааран тухайн байгууллагаас тусгаарлах буюу хуваах ба дангаар нь, эсвэл холбогдох заавал биелүүлэх хэлцэл, тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөртэй хамтад нь худалдах, шилжүүлэх, лицензээр эзэмшүүлэх, түрээслүүлэх, арилжих боломжтой байх; эсвэл
- (б) Заавал биелүүлэх хэлцлийн эрхүүдийг (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхийг) шилжүүлж болох, эсвэл тухайн байгууллагаас болон бусад эрх, үүргээс салган тусгаарлах боломжтой эсэхээс үл хамааран заавал биелүүлэх хэлцлээс үүсдэг байх.

Хамтын байгууллага гэдэг нь өөрийн эзэд, гишүүд болон оролцогчдод ногдол ашиг, өртөг зардлын хямдруулалт болон бусад эдийн засгийн үр өгөөжийг шууд олгодог, хөрөнгө оруулагчийн өмчилдөг

байгууллагаас бусад, байгууллага юм. Жишээлбэл; хамтарсан даатгалын компани, зээлийн холбоо болон хоршоо нь бүгд хамтын байгууллага болно.

Үйл ажиллагаа гэдэг нь бараа, үйлчилгээ нийлүүлэх замаар тухайн байгууллагын зорилтуудад хүрэхийн тулд эрхлэн явуулж, удирдан зохицуулах боломжтой нэгдмэл цогц үйл ажиллагаа ба холбогдох хөрөнгө, өр төлбөр юм.

Энэ Стандартын зорилгын хувьд, тухайн үйл ажиллагаанд тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоо бүхий аливаа талыг хамруулахын тулд эзэд гэсэн ойлголтыг өргөн утгатайгаар ашигладаг. Үүнд: хөрөнгө оруулагчийн өмчилдөг байгууллагуудын өмчлөлийн хувь оролцооны эзэмшигчид болон хамтын байгууллагын эзэд, гишүүд буюу оролцогчид хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй.

Ерөнхий хяналтанд буй улсын секторын нэгдэл гэдэг нь хамаарах бүх байгууллагууд буюу үйл ажиллагааг уг улсын секторын нэгдлийн өмнө болон дараа тухайн нэг байгууллага эцэстээ хянадаг улсын секторын нэгдэл юм.

## Нийлүүлэлттэй холбоотой тодорхойлолтууд

Нийлүүлэлт гэдэг нь үр дүнгийн байгууллага үүсэн бий болгоход хүргэдэг бөгөөд дараах хоёрын аль нэг байна:

- (а) Тухайн нэгдэлд оролцогч аль нэг тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаггүй улсын секторын нэгдэл; эсвэл
- (б) Тухайн нэгдэлд оролцогч нэг тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг бөгөөд нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанарыг тэрхүү нэгдэл агуулсан гэсэн нотолгоотой байх улсын секторын нэгдэл.

(Нэмэлт заавар удирдамжийг МЗУ1-р параграфт тусгасан.)

Нийлүүлэх өдөр гэдэг нь нэгдэгч үйл ажиллагаануудын хяналтыг тухайн үр дүнгийн байгууллага олж авсан өдөр юм.

Нэгдэгч үйл ажиллагаа гэдэг нь нийлүүлэлтээр үр дүнгийн байгууллагыг үүсгэн бий болгохын тулд нэг буюу хэд хэдэн өөр үйл ажиллагаануудыг нэгтгэдэг үйл ажиллагаа юм.

Үр дүнгийн байгууллага гэдэг нь нийлүүлэлтээр нэгдэж буй хоёр буюу хэд хэдэн үйл ажиллагаануудын үр дүн болох байгууллага юм (Нэмэлт заавар удирдамжийг МЗУ1-р параграфт тусгасан).

## **Худалдан авалттай холбоотой тодорхойлолтууд**

Худалдан авсан үйл ажиллагаа гэдэг нь худалдан авалтын үр дүнд хяналтыг нь нэгтгэгч олж авсан үйл ажиллагаа юм.

Нэгтгэгч гэдэг нь худалдан авалтын үр дүнд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан байгууллага юм.

Худалдан авалт гэдэг нь нэгдэлд оролцогч нэг тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг бөгөөд уг нэгдэл нь нийлүүлэлт биш гэсэн нотолгоотой байх улсын секторын нэгдэл юм.

Худалдан авалтын өдөр гэдэг нь уг худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг нэгтгэгч олж авсан өдөр юм.

Болзошгүй төлбөр гэдэг нь тусгайлан тохиролцсон ирээдүйн үйл явдал гарч тохиолдох буюу нөхцөл хангагдвал уг худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг авах арилжааны нэг хэсэг байдлаар тэрхүү худалдан авсан үйл ажиллагааны хуучин эздэд нэмэлт хөрөнгө буюу өмчийн хувь оролцоог ихэвчлэн шилжүүлэх нэгтгэгчийн үүрэг юм. Гэхдээ болзошгүй төлбөр нь хэрэв тусгайлан тохиролцсон нөхцөл хангагдвал өмнө шилжүүлсэн төлбөрийг буцаан авах эрхийг нэгтгэгчид мөн олгож болох юм.

Гүүдвил нь худалдан авалтаар олж эзэмшсэн бусад хөрөнгүүдээс үүсдэг бөгөөд бие даасан байдлаар тодорхойлж, тусад нь хүлээн зөвшөөрдөггүй ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлэх хөрөнгө юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

## **Улсын секторын нэгдлийг тодорхойлох**

6. Хөрөнгүүд болон өр төлбөрүүд нь үйл ажиллагааг үүсгэн бүрдүүлэхийг шаарддаг энэ Стандартын тодорхойлолтыг ашигласнаар ажил гүйлгээ буюу бусад үйл явдал нь улсын секторын нэгдэл мөн эсэхийг байгууллага тодорхойлно. Хэрэв хөрөнгө болон өр төлбөр нь үйл ажиллагааг үүсгэн бүрдүүлэхгүй бол тухайн байгууллага нь уг ажил гүйлгээ буюу бусад үйл явдлыг бусад УСНББОУС-ын дагуу тайлагнана. Улсын секторын нэгдлийг тодорхойлох заавар удирдамжийг МЗУ2-МЗУ9-р параграфт тусгасан.

## **Улсын секторын нэгдлийн ангилал**

7. Улсын секторын нэгдлийн оролцогч аль нэг тал нь тухайн нэгдлийн үр дүнд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаггүй

бол уг нэгдлийг нийлүүлэлт гэж ангилна. Улсын секторын нэгдлийн оролцогч нэг тал нь тухайн нэгдлийн үр дүнд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг эсэхийг тодорхойлох талаархи заавар удирдамжийг МЗУ10-МЗУ18-р параграфт тусгасан.

8. Улсын секторын нэгдлийн оролцогч аль нэг тал нь тухайн нэгдлийн үр дүнд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг бол тус байгууллага нь уг нэгдлийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилахдаа тэрхүү нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзнэ. Оролцогч аль нэг тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг нэгдэл нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай байхаас бусад тохиолдолд түүнийг худалдан авалт гэж ангилна.
9. Улсын секторын нэгдлийн ангиллыг тодорхойлохдоо байгууллага нь тухайн нэгдэлд хэрэглэх нягтлан бодох бүртгэлийн арга нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэх бөгөөд чанарын шинжүүд (ЧШ)-ийг хангах мэдээллийг бий болгох эсэхийг харгалзан үзнэ. Нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг үнэлэхдээ байгууллага нь 12-13-р параграфт дурдсан, төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Нэгдэл нь нийлүүлэлттэй адил эдийн засгийн мөн чанартай эсэх талаархи нотолгоог эдгээр үзүүлэлтүүд нь дангаараа эсвэл хамтдаа ихэвчлэн бүрдүүлдэг. Нийлүүлэлт гэж ангилагдахын тулд нэгдэл нь эдгээр хоёр хэсэг үзүүлэлтүүдийн аль алиныг хангасан байх албагүй юм. Нэмэлт заавар удирдамжийг МЗУ19-МЗУ39-р параграфт тусгасан.
10. 12-13-р параграфт дурдсан, төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийн болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийн шинжилгээ нь ихэвчлэн дүгнэлтийн шинжтэй үр дүнг гаргадаг бөгөөд уг нэгдэл нь нийлүүлэлт мөн эсэхийг тодорхойлохын тулд тухайн улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарын талаархи хангалттай нотолгоог бүрдүүлдэг. Ийм тохиолдолд үүний үр дүн болох ангилал болон холбогдох нягтлан бодох бүртгэлийн арга хандлага нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэх ба ЧШ-ийг хангах тийм мэдээллийг хэрэглэгч нар авах нөхцлийг бүрдүүлдэг.
11. Хэвийн бус гажих тохиолдолд, 12-13-р параграфт дурдсан үзүүлэлтүүдийг ашигласны дараах үр дүн нь дүгнэлтийн бус шинжтэй буюу улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарын талаархи хангалттай нотолгоог бүрдүүлдэггүй байж болох юм. Ийм тохиолдолд аль ангилал нь тухайн санхүүгийн тайлагналын зорилтуудыг хамгийн сайнаар биелүүлэх ба ЧШ-ийг хамгийн сайнаар хангах тийм мэдээллийг бүрдүүлэх эсэхийг байгууллага нь 14-р параграфт заасны дагуу мөн харгалзан үзнэ.

**Нэгдэл нь нийлүүлэлт гэсэн нотолгоогоор хангаж болох үзүүлэлтүүд**

*Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд*

12. Дараах үзүүлэлтүүд нь уг нэгдэл бол нийлүүлэлт гэсэн нотолгоогоор хангаж болох юм:
- (а) Шилжүүлсэн үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд тэдгээр эрхтэй талуудад нөхөн төлбөр болгон төлөхөөс бусад шалтгаанаар төлбөр төлөх (нэмэлт заавар удирдамжийг МЗУ27-МЗУ28-р параграфт тусгасан);
  - (б) Шилжүүлсэн үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй талуудад төлбөр төлөхгүй байх (нэмэлт заавар удирдамжийг МЗУ29-МЗУ30-р параграфт тусгасан); эсвэл
  - (в) Шилжүүлсэн байгууллагын цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй нэг ч тал (хувь хүн эсвэл байгууллага) байхгүйн улмаас төлбөр төлөхгүй байх (нэмэлт заавар удирдамжийг МЗУ31-р параграфт тусгасан).

*Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүд*

13. Дараах үзүүлэлтүүд нь уг нэгдэл бол нийлүүлэлт гэсэн нотолгоогоор хангаж болох юм:
- (а) Нэгдлийн аль нэг тал нь шийдвэр гаргах үйл явцад оролцохгүйгээр тухайн улсын секторын нэгдлийг гуравдагч тал гүйцэтгэх (нэмэлт заавар удирдамжийг МЗУ32-МЗУ35-р параграфт тусгасан);
  - (б) Улсын секторын нэгдлийг оролцогч тал тус бүрийн иргэдийн санал асуулгаар зөвшөөрдөг байх (нэмэлт заавар удирдамжийг МЗУ36-р параграфт тусгасан); эсвэл
  - (в) Ерөнхий хяналтанд буй улсын секторын нэгдэл хийгдсэн байх (нэмэлт заавар удирдамжийг МЗУ37-МЗУ39-р параграфт тусгасан).

*Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүд нь уг нэгдлийг нийлүүлэлт гэж үзэх эсэхийг тодорхойлох хангалттай нотолгоог бүрдүүлдэггүй тохиолдолд харгалзан үзэх нэмэлт асуудлууд*

14. Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийн болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийн шинжилгээ нь хэвийн бус гажих тохиолдолд дүгнэлтийн бус шинжтэй үр дүн гаргах буюу уг улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанар ба 12-13-р параграфт дурдсан үзүүлэлтүүдэд үндэслэн авч үзэхэд тухайн улсын секторын нэгдэл нь нийлүүлэлт мөн эсэхийг тодорхойлох хангалттай нотолгоог бүрдүүлдэггүй байж болох юм. Ийм нөхцөлд аль ангилал болон түүний үр дүн болох нягтлан бодох бүртгэлийн ямар арга хандлага нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хамгийн сайнаар биелүүлэх тийм мэдээллээр хангах эсэхийг байгууллага нь харгалзан үзнэ. Нэмэлт заавар удирдамжийг МЗУ42-МЗУ46-р параграфт тусгасан. Аль ангилал болон түүний үр дүн болох нягтлан бодох бүртгэлийн

ямар арга хандлага нь хамааралтай, үнэн зөв толилуулга, ойлгомжтой байдал, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх ба шалгах боломжтой байдал гэсэн чанарын шинжүүдийг хамгийн сайнаар хангах тийм мэдээллийг бүрдүүлэх эсэхийг байгууллага нь харгалзан үзнэ. Нэмэлт заавар удирдамжийг МЗУ47-МЗУ50-р параграфт тусгасан.

## **Нийлүүлэлтийн тайлагнал**

15. **Үр дүнгийн байгууллага нь хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг ашигласнаар нийлүүлэлт нэг бүрийг тайлагнана.**

## **Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга**

16. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг хэрэглэхдээ дараах зүйлсийг гүйцэтгэхийг шаарддаг:
- (а) Үр дүнгийн байгууллагыг тогтоох;
  - (б) Нийлүүлэх өдрийг тодорхойлох;
  - (в) Олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон нэгдэгч үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог УСНББОУС-ын шаардлагуудын дагуу хүлээн зөвшөөрөх ба хэмжих;
  - (г) Нийлүүлэлтээс бий болсон цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүд болон бусад тохируулгыг хүлээн зөвшөөрч, хэмжих.

## **Үр дүнгийн байгууллагыг тогтоох**

17. **Нийлүүлэлт нэг бүрийн хувьд үр дүнгийн байгууллагыг тогтооно.**
18. Энэ Стандартын 5-р параграфт үр дүнгийн байгууллагыг “нийлүүлэлтээр нэгдэж буй хоёр буюу хэд хэдэн үйл ажиллагаануудын үр дүн болох байгууллага” гэж тодорхойлсон. Иймээс үр дүнгийн байгууллагыг нийлүүлэлтийн үр дүн болох нэгдэгч үйл ажиллагаануудын хяналтыг олж авсан байгууллага гэж цаашид тодорхойлно.

## **Нийлүүлэх өдрийг тодорхойлох**

19. **Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэх өдрийг тодорхойлох бөгөөд энэ нь уг нэгдэгч үйл ажиллагаануудын хяналтыг олж авсан өдөр байна.**
20. Нэгдэгч үйл ажиллагаануудын хяналтыг үр дүнгийн байгууллага олж авсан өдөр нь уг үр дүнгийн байгууллага тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын хөрөнгийг олж эзэмшсэн ба өр төлбөрийг хариуцсан өдөр байж болох юм. Үр дүнгийн байгууллага нь нэгдэгч үйл ажиллагааны хөрөнгийн хууль ёсны эрхийг олж аваагүй эсвэл уг нэгдэгч үйл ажиллагааны өр төлбөрийн хувьд хуулийн хариуцлага хүлээдэггүй байж болно. Энэ тохиолдолд хөрөнгө ба өр төлбөрийн эрх, үүргийг уг үр дүнгийн байгууллагад албан ёсоор



шилжүүлсэн өдөр тус үр дүнгийн байгууллага нь тухайн нэгдэгч үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн хяналтыг ихэвчлэн олж авдаг. Гэхдээ үр дүнгийн байгууллага нь хяналтыг дээр дурдсанаас өөр өдөр олж авч болох юм. Тухайлбал; үр дүнгийн байгууллага нь уг нэгдэгч үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн хяналтыг тодорхой өдөр олж авна гэдгийг хууль тогтоомж буюу бичгэн хэлцэлд заасан байж болно. Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэх өдрийг тогтоохдоо холбогдох бүх баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

**Тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон нэгдэгч үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба хэмжих**

*Хүлээн зөвшөөрөлтийн зарчим*

21. Үр дүнгийн байгууллага нь нэгдэгч үйл ажиллагааны санхүүгийн тайланд уг нийлүүлэх өдрөөр хүлээн зөвшөөрсөн байгаа тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон аливаа хяналтын бус хувь оролцоог тэрхүү нийлүүлэх өдрөөр хүлээн зөвшөөрнө. Олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт нь 22-23-р параграфт тусгайлан заасан нөхцлүүдэд захирагдана.

*Хүлээн зөвшөөрөлтийн нөхцлүүд*

22. Нэгдэгч үйл ажиллагаануудын хооронд гарсан бүх ажил гүйлгээний үр нөлөөг уг үр дүнгийн байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэхдээ устгаж цэвэрлэнэ (холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ51-МЗУ52-р параграфт тусгасан).

23. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан аргын мөрдөлтийн нэг хэсэг болгон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахын тулд тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөр нь *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал*-д заасан хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолтыг уг нийлүүлэх өдөр хангасан байх ёстой. Жишээлбэл; нэгдэгч үйл ажиллагааны эрхлэн явуулдаг үйл ажиллагаануудыг зогсоох, эсвэл нэгдэгч үйл ажиллагааны ажилтнуудын ажил эрхлэлтийг дуусгавар болгох буюу ажилтнуудыг өөр ажилд шилжүүлэх өөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ирээдүйд гарна гэж уг үр дүнгийн байгууллагын хүлээж байгаа боловч хариуцах үүрэг хүлээгээгүй байгаа өртөг зардал нь тухайн нийлүүлэх өдрөөрх өр төлбөр биш юм. Иймээс үр дүнгийн байгууллага нь хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан аргын мөрдөлтийн нэг хэсэг байдлаар эдгээр зардлыг хүлээн зөвшөөрөхгүй. Харин үр дүнгийн байгууллага нь нэгдлийн дараах санхүүгийн тайландаа эдгээр зардлыг бусад холбогдох УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрнө.

Нийлүүлэлтэнд хамаарах хөрөнгө, өр төлбөрийг ангилах буюу сонгох

24. **Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтээр олж эзэмшсэн хөрөнгө, хариуцсан өр төлбөрийг уг нэгдэгч үйл ажиллагаануудын өмнө мөрдөж байсан ангилал буюу сонголтыг ашигласнаар тэрхүү нийлүүлэх өдөр ангилах буюу сонгоно. Бусад УСНББОУС-аар зөвшөөрдөг байлаа ч гэсэн үр дүнгийн байгууллага нь анх хүлээн зөвшөөрөх үед өөр ангилал буюу сонголтыг ашиглахгүй.**
25. Байгууллага нь тодорхой хөрөнгө, өр төлбөрийг хэрхэн ангилдаг буюу сонгодог эсэхээс хамааран нягтлан бодох бүртгэл нь зарим тохиолдолд өөр өөр байхаар УСНББОУС-д заасан байдаг. Нэгдэгч үйл ажиллагаануудын өмнө ашиглаж байсан ангилал буюу сонголтонд үндэслэн тухайн үр дүнгийн байгууллага нь ангилал буюу сонголтыг хийх жишээнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
- (а) УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн дагуу бодит үнэ цэнээр эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжсэн гэж ангилсан тухайн тодорхой санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн ангилал;
  - (б) Үүсмэл хэрэглүүрийг УСНББОУС 29-ийн дагуу хейжийн хэрэглүүр гэж ангилах сонголт; ба
  - (в) Дагалдах үүсмэл хэрэглүүрийг УСНББОУС 29-ийн дагуу үндсэн гэрээнээс салган тусгаарлах хэрэгтэй эсэх үнэлгээ (уг нэр томъёог энэ Стандартад ашиглах үед энэ нь “ангилал”-д хамаарах асуудал байна).

*Хэмжилтийн зарчим*

26. **Нэгдэгч үйл ажиллагаануудын тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийг тэрхүү үр дүнгийн байгууллага нь тухайн нэгдэгч үйл ажиллагаануудын санхүүгийн тайлан дахь тэдгээрийн дансны үнээр уг нийлүүлэх өдөр хэмжих бөгөөд энэ нь 27-р параграфын шаардлагад захирагдана (холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ53-МЗУ54-р параграфт тусгасан).**
27. **Үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэх шаардлагатай тохиолдолд тэрхүү үр дүнгийн байгууллага нь тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг уг нийлүүлэх өдрөөр тохируулна.**
28. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан арга нь нэгдсэн нэг үр дүнгийн байгууллага үүсэн бий болоход хүргэдэг. Тухайн байгууллага нь УСНББОУС-ын шаардлагуудад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл нэг цогц бодлогыг мөрдөх бөгөөд тэрхүү нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэх шаардлагатай болсон тохиолдолд уг нэгдэгч үйл ажиллагаануудын тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг тохируулна.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

29. Нэгдэгч үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог үр дүнгийн байгууллага нь тухайн нэгдэгч үйл ажиллагааны санхүүгийн тайлан дахь тэдгээрийн дансны үнээр уг нийлүүлэх өдөр хэмжих бөгөөд 27-р параграфын дагуу хийсэн тохируулгаас энэ хяналтын бус хувь оролцоонд хамаарах хувь тэнцүүлсэн хэсгийн хувьд тэрхүү дансны үнийг тохируулна.
30. Хэмжилтийн зарчмын хувьд хязгаарлагдмал гажих нөхцлийг энэхүү Стандартаар олгодог тийм зүйлсийг өөртөө агуулсан тухайн тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн төрлүүдийг 33-35-р параграфт тусгайлан заасан.

### *Хүлээн зөвшөөрөлтийн буюу хэмжилтийн зарчмуудын гажих нөхцлүүд*

31. Энэ Стандарт нь түүний хүлээн зөвшөөрөлтийн буюу хэмжилтийн зарчмуудын хязгаарлагдмал гажих нөхцлүүдийг заасан байдаг. Гажих нөхцлүүдийг хэрэглэх тухайн тодорхой зүйлс болон тэдгээр гажих нөхцлүүдийн шинж төрлийг 32-35-р параграфт тусгайлан заасан. Үр дүнгийн байгууллага нь 32-35-р параграфын шаардлагуудыг мөрдсөнөөр тэдгээр зүйлсийг тайлагнах бөгөөд ингэснээр зарим зүйлсийг дараах байдлаар тусгахад хүргэдэг:
  - (а) 22-23 -р параграфт заасан нөхцлүүдээс гадна хүлээн зөвшөөрөлтийн нөхцлийг даган мөрдснөөр, эсвэл уг хүлээн зөвшөөрөлтийн зарчим ба нөхцлүүдийг мөрдснөөс өөр үр дүн бүхий бусад УСНББОУС-уудын шаардлагуудыг даган мөрдснөөр хүлээн зөвшөөрөх.
  - (б) Нийлүүлэх өдрөөрх тэдгээрийн дансны үнээс өөр дүнгээр хэмжих.

### *Хүлээн зөвшөөрөлтийн зарчмын гажих нөхцөл*

Нэгдэгч нэг үйл ажиллагаа нь нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө нь олгосон лиценз ба адилтгах эрхүүд

32. Нэгдэгч нэг үйл ажиллагаанаас нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө олгосон бөгөөд хүлээн авч буй уг нэгдэгч үйл ажиллагаа нь биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн лиценз буюу адилтгах эрхийг тухайн үр дүнгийн байгууллага нь биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Ийм лиценз буюу адилтгах эрхийг 22-р параграфын дагуу устгаж цэвэрлэхгүй (холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ55-МЗУ56-р параграфт тусгасан).

### *Хүлээн зөвшөөрөлтийн болон хэмжилтийн зарчмуудын аль алины гажих нөхцлүүд*

#### *Орлогын албан татвар (Нийлүүлэлтийн нөхцөлд тусгагдсан тохиолдолд)*

33. Улсын секторын байгууллагуудыг хамарсан нийлүүлэлт нь тухайн төлөх ёстой татварыг уг нийлүүлэлтийн нөхцлийн нэг хэсэг байдлаар татварын эрх бүхий байгууллагаас чөлөөлөхөд хүргэж болох юм. Тухайн үр дүнгийн байгууллага нь уг нийлүүлэлтийн нөхцлийн үр дүнд чөлөөлөгдсөн аливаа татвар ногдох зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй (холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ57-МЗУ58-р параграфт тусгасан).

34. Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтэнд тусган оруулсан буюу түүнээс үүссэн аливаа үлдсэн татвар ногдох зүйлсийг орлогын албан татварыг зохицуулдаг, нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ. Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтэнд тусган оруулсан буюу түүнээс үүссэн аливаа үлдсэн орлогыг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ.

**Ажилтны тэтгэмж**

35. Үр дүнгийн байгууллага нь уг нэгдэгч үйл ажиллагааны ажилтны тэтгэмжийн хэлцэлтэй холбоотой өр төлбөр (хэрэв байгаа бол хөрөнгө)-ийг УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ.

**Нийлүүлэлтийн үр дүнд үүссэн цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих**

36. **Нийлүүлэлт нь гүүдвил үүсэхэд хүргэдэггүй (холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ59-МЗУ60-р параграфт тусгасан).**
37. **Үр дүнгийн байгууллага нь дараах зүйлстэй тэнцүү бөгөөд эсрэг утгатай дүнг цэвэр хөрөнгө/өмчийн хүрээнд хүлээн зөвшөөрнө:**
- (a) **Нэгдэгч үйл ажиллагааны хөрөнгийн дансны үнэ;**
  - (б) **Нэгдэгч үйл ажиллагааны өр төлбөрийн дансны үнэ; ба**
  - (в) **Нэгдэгч үйл ажиллагааны хяналтын бус хувь оролцооны дансны үнэ.**
38. **Үр дүнгийн байгууллага нь дараах зүйлсийн хувьд харгалзах тохируулгыг цэвэр хөрөнгө/өмчийн хүрээнд хүлээн зөвшөөрнө:**
- (a) **Нэгдэгч үйл ажиллагаануудын хооронд хийсэн ажил гүйлгээг 22-р параграфын дагуу устгаж цэвэрлэх;**
  - (б) **Үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэх шаардлагатай тохиолдолд нэгдэгч үйл ажиллагааны тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд 27-р параграфын дагуу хийсэн тохируулга; ба**
  - (в) **Хүлээн зөвшөөрөлтийн ба/буюу хэмжилтийн зарчмуудын гажих нөхцлүүдийн хувьд 32-35 –р параграфын дагуу хийсэн тохируулга.**
39. **Үр дүнгийн байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг 37 ба 38-р параграфын дагуу дараах аль нэг байдлаар толилууулж болно:**
- (a) **Эхний үлдэгдлийн нэг дүн; эсвэл**
  - (б) **Цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэг байдлаар.**

**Хэмжилтийн хугацаа**

40. Нийлүүлэлтийн анхны тайлагнал нь уг нийлүүлэлт хийгдсэн тайлант үеийн эцэст бүрэн дуусаагүй байсан бол үр дүнгийн байгууллага нь хараахан тайлагнаж дуусаагүй байгаа зүйлсийн хувьд тооцсон нөхцөлт дүнг өөрийн санхүүгийн тайланд тусгана. Нийлүүлэлтийн өдрөөр оршин байсан бөгөөд хэрэв мэдэгдсэн бол уг өдрөөр хүлээн зөвшөөрсөн дүнгийн хэмжилтэнд нөлөөлөх байсан баримт материал болон нөхцөл байдлын талаар олж авсан шинэ мэдээллийг тусгахын тулд үр дүнгийн байгууллага нь тэрхүү нийлүүлэх өдөр хүлээн зөвшөөрсөн, нөхцөлт дүнгүүдийг тухайн хэмжилтийн хугацааны туршид буцаах горимоор залруулна. Нийлүүлэлтийн өдрөөр оршин байсан бөгөөд хэрэв мэдэгдсэн бол уг өдрөөрх тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтөнд хүргэх байсан баримт материал болон нөхцөл байдлын талаар шинэ мэдээлэл олж авсан тохиолдолд үр дүнгийн байгууллага нь тэрхүү нэмэлт хөрөнгө буюу өр төлбөрийг тухайн хэмжилтийн хугацааны туршид мөн хүлээн зөвшөөрнө. Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэх өдрөөр оршин байсан баримт материал ба нөхцөл байдлын талаар эрэлхийлж байсан мэдээллийг хүлээн авсан буюу өөр мэдээлэл олж авах боломжгүй гэдгийг тогтоосноор тухайн хэмжилтийн хугацаа дуусгавар болдог. Гэхдээ хэмжилтийн хугацаа нь тухайн нийлүүлэх өдрөөс хойш нэг жилээс хэтрэхгүй байна.
41. Хэмжилтийн хугацаа гэдэг нь нийлүүлэлтийн хувьд хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнд уг үр дүнгийн байгууллага залруулга хийж болох, тухайн нийлүүлэх өдрөөс хойшхи хугацаа юм. Хэмжилтийн хугацаа нь тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөр болон нэгдэгч үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог энэ Стандартын шаардлагуудын дагуу уг нийлүүлэх өдрөөр тодорхойлж, хэмжихэд шаардлагатай мэдээллийг олж авах ул үндэслэлтэй хугацаагаар тэрхүү үр дүнгийн байгууллагыг хангадаг. Тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөр болон нэгдэгч үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог тодорхойлж, хэмжихэд шаардлагатай мэдээллийг уг нийлүүлэх өдрөөр ерөнхийдөө олж авах боломжтой байдаг. Гэхдээ нэгдэгч үйл ажиллагаанууд нь нягтлан бодох бүртгэлийн өөр өөр бодлогуудыг ашигласнаар өөрсдийн санхүүгийн тайланг өмнө нь бэлтгэдэг байсан бол ийм нөхцөл үүсэхгүй байж болох юм.
42. Үр дүнгийн байгууллага нь 37-38-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг залруулснаар уг тодорхойлогдох хөрөнгө (өр төлбөр)-ийн хувьд хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнгийн нэмэгдэлт (бууралт)-ийг хүлээн зөвшөөрнө. Гэвч хэмжилтийн хугацааны туршид олж авсан шинэ мэдээлэл нь зарим тохиолдолд нэгээс олон хөрөнгө буюу өр төлбөрийн нөхцөлт дүнд залруулга хийхэд хүргэж болох юм. Жишээлбэл; үр дүнгийн байгууллага нь нэгдэгч аль нэг үйл ажиллагааны хөрөнгөнд учрах эвдрэл гэмтэлтэй холбоотой хохирлыг төлөх үүргийг хүлээсэн байж болох бөгөөд тэдгээр нь бүхэлдээ эсвэл зарим хэсэг нь тухайн нэгдэгч үйл ажиллагааны хариуцлагын даатгалын гэрээгээр хамгаалагдсан байдаг. Хэрэв үр дүнгийн байгууллага нь уг үүргийн дансны

үнийн талаархи шинэ мэдээллийг тухайн хэмжилтийн хугацаанд олж авсан бол тэрхүү өр төлбөрийн хувьд хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнгийн өөрчлөлтийн улмаас олз, гарзад хийгдэх залруулга ба даатгагчаас нэхэмжилсэн авлагын хувьд хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнгийн өөрчлөлтийн үр дүн болох олз, гарзын харгалзах залруулгыг (бүхэлд нь буюу хэсэгчлэн) харилцан суутгаж, цэвэр дүнгээр тооцно.

43. Нөхцөлт дүнгүүдэд хийх залруулгыг уг үр дүнгийн байгууллага нь тэрхүү нийлүүлэлтийн тайлагналыг тухайн нийлүүлэх өдрөөр бүрэн дуусгасан мэтээр хэмжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрнө. Иймээс үр дүнгийн байгууллага нь санхүүгийн тайланд толилуулсан өмнөх тайлант үеүдийн хувьд зэрэгцүүлэгдэх мэдээллийг шаардлагатай хэмжээгээр хянан засварлана, үүн дотроо уг анхны тайлагналын үед хүлээн зөвшөөрсөн элэгдэл буюу хорогдуулгын аливаа өөрчлөлтийг тусгана.
44. Хэмжилтийн хугацаа дууссаны дараа, уг үр дүнгийн байгууллага нь зөвхөн алдааг засварлахын тулд нийлүүлэлтийн тайлагналыг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого*, *Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу засварлан өөрчилнө.

#### **Нийлүүлэлттэй холбоотой зардал**

45. Нийлүүлэлттэй холбоотой зардал нь уг нийлүүлэлтийг хийхийн тулд тухайн үр дүнгийн байгууллагын болон нэгдэгч үйл ажиллагаануудын гаргасан зардал юм. Үүнд дараах зардал хамаарна: зөвлөх, хуулийн, нягтлан бодох бүртгэлийн, үнэлгээний болон бусад мэргэжилтний буюу зөвлөх үйлчилгээний хөлс; ерөнхий удирдлагын зардал; өрийн болон өмчийн үнэт цаасыг бүртгүүлэх ба гаргах зардал. Үр дүнгийн байгууллага болон нэгдэгч үйл ажиллагаанууд нь нийлүүлэлттэй холбоотой өртөг зардлыг ганцхан тохиолдлоос бусад үед зардал гарсан ба үйлчилгээг хүлээн авсан тайлант үед зардал гэж тайлагнана. Харин өрийн болон өмчийн үнэт цаас гаргахтай холбоотой зардлыг УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Топилуулга* ба УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрнө.

#### **Дараагийн тайлант үеийн хэмжилт ба нягтлан бодох бүртгэл**

46. Ерөнхийдөө, үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтээр олж эзэмшсэн хөрөнгө, өр төлбөр, болон гаргасан өмчийн хэрэглүүрийг тэдгээрийн шинж төрлөөс хамааран тухайн зүйлсэд мөрдөх бусад холбогдох УСНББОУС-уудын дагуу дараагийн тайлант үед хэмжиж, тайлагнана. Гэхдээ энэ Стандарт нь нийлүүлэлтээр олж эзэмшсэн дараах хөрөнгө, хариуцсан буюу хүлээсэн өр төлбөрийг дараагийн тайлант үед хэмжих ба тайлагнах талаархи заавар удирдамжаар хангана:
- (а) Нэгдэгч нэг үйл ажиллагаа нь нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө нь олгосон лиценз ба адилтгах эрхүүд;
  - (б) Нийлүүлэлтийн үр дүнд өөрчлөгдөх шалгуурт үндэслэн уг нэгдэгч үйл ажиллагааны хүлээн авсан шилжүүлэг, хөнгөлөлттэй зээл ба адилтгах өгөөж; ба

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (в) Орлогын албан татвар (нийлүүлэлтийн нөхцөлд тусгаагүй тохиолдолд).

*Нэгдэгч нэг үйл ажиллагаа нь нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө нь олгосон лиценз ба адилтгах эрхүүд*

47. Нэгдэгч нэг үйл ажиллагаа нь нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө нь олгосон бөгөөд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн, лиценз буюу адилтгах эрхийг тодорхой хугацаатайгаар олгосон тохиолдолд уг эрх олгосон заавал биелүүлэх хэлцлийн үлдсэн хугацааны туршид тэрхүү эрхийг хорогдуулна. Эрхийг тодорхой бус хугацаагаар олгосон бол уг үр дүнгийн байгууллага нь эрхийн үнэ цэнийн бууралтыг наад зах нь жил тутам болон үнэ цэнэ буурсан байж болох шинж тэмдэг илэрсэн аливаа тохиолдолд сорьж шалгана. Энэхүү лиценз буюу адилтгах эрхийг дараагийн тайлант үед гуравдагч талд борлуулдаг уг үр дүнгийн байгууллага нь борлуулалтын олз буюу гарзыг тодорхойлохдоо тухайн биет бус хөрөнгийн дансны үнийг харгалзан тусгана.

*Нийлүүлэлтийн үр дүнд өөрчлөгдөж болох шалгуурт үндэслэн тухайн нэгдэгч үйл ажиллагааны хүлээн авсан шилжүүлэг, хөнгөлөлттэй зээл ба адилтгах өгөөж*

48. Нийлүүлэлтийн үр дүнд өөрчлөгдөх шалгуурт үндэслэн тухайн нэгдэгч үйл ажиллагааны өмнө хүлээн авсан шилжүүлэг, хөнгөлөлттэй зээл ба адилтгах өгөөжийг бусад УСНББОУС-уудын дагуу гүйцээх горимоор дахин үнэлнэ (холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ61-МЗУ63-р параграфт тусгасан).

*Орлогын албан татвар (нийлүүлэлтийн нөхцөлд тусгаагүй тохиолдолд)*

49. Улсын секторын байгууллагуудыг хамарсан нийлүүлэлт нь татварын эрх бүхий байгууллага уг нийлүүлэлтийн дараах татварыг чөлөөлөхөд хүргэж болох юм. Тухайн үр дүнгийн байгууллага нь орлогын татварыг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу уг чөлөөлөгдсөн татварыг гүйцээх горимоор тайлагнана.

### **Санхүүгийн тайлангийн толилуулга**

50. **Үр дүнгийн байгууллага нь улсын секторын нэгдлийн дараа шинэ байгууллага байхаас бусад тохиолдолд тэрхүү нийлүүлэлтийн дараах уг үр дүнгийн байгууллагын анхны иж бүрэн санхүүгийн тайлан нь дараах зүйлсийг агуулсан байна:**

- (а) **Нийлүүлэх өдрөөрх эхлэлийн санхүүгийн байдлын тайлан;**
- (б) **Тайлангийн өдрөөрх санхүүгийн байдлын тайлан;**
- (в) **Нийлүүлэх өдрөөс тайлангийн өдөр хүртэлх хугацааны санхүүгийн үр дүнгийн тайлан;**
- (г) **Нийлүүлэх өдрөөс тайлангийн өдөр хүртэлх хугацааны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан;**

- (д) **Нийлүүлэх өдрөөс тайлангийн өдөр хүртэлх хугацааны мөнгөн гүйлгээний тайлан;**
  - (е) **Байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулдаг тохиолдолд тусдаа нэмэлт санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан дахь төсвийн багана байдлаар харуулсан, нийлүүлэх өдрөөс тайлангийн өдөр хүртэлх хугацааны төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлт;**
  - (ж) **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба бусад тайлбар мэдээллээс бүрдэх тодруулга.**
51. **Үр дүнгийн байгууллага нь улсын секторын нэгдлийн дараа шинэ байгууллага биш байх тохиолдолд уг үр дүнгийн байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (а) **Нэгдэгч үйл ажиллагаануудаас уг үр дүнгийн байгууллагад тусган оруулсан хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийн гол анги тус бүрийн хүлээн зөвшөөрсөн дүн;**
  - (б) **Нэгдэгч үйл ажиллагаануудын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг уг үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд шаардлагатай болсон тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хийсэн аливаа тохируулга; ба**
  - (в) **Нэгдэгч үйл ажиллагаануудын хооронд хийгдсэн ажил гүйлгээнүүдийг устгаж цэвэрлэхийн тулд хийсэн аливаа тохируулга.**
52. 54 ба 56-р параграфын шаардлагуудын дагуу, уг үр дүнгийн байгууллага нь нийлүүлэх өдрөөс өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайланг толилуулахыг зөвшөөрөх боловч заавал шаардахгүй (холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ64-МЗУ65-р параграфт тусгасан). Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэх өдрөөс өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайланг толилуулах сонголт хийсэн тохиолдолд 54(ж) параграфтаар шаардсан мэдээллийг тодруулна.

### **Тодруулга**

53. **Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтийн шинж төрөл ба санхүүгийн үр нөлөөг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна.**
54. 53-р параграфт дурдсан зорилгыг биелүүлэхийн тулд үр дүнгийн байгууллага нь тухайн тайлант үеийн туршид хийгдсэн нийлүүлэлт тус бүрийн хувьд дараах мэдээллийг тодруулна:
- (а) **Нэгдэгч үйл ажиллагааны нэр ба тайлбар тодорхойлолт.**
  - (б) **Нийлүүлэх өдөр.**



## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (в) Нийлүүлэлт хийх үндсэн шалтгаан, үүн дотроо хэрэв боломжтой бол тухайн нийлүүлэлтийн хууль зүйн үндэслэл.
  - (г) Шилжүүлсэн хөрөнгө ба өр төлбөрийн гол анги тус бүрийн хувьд уг нийлүүлэх өдрөөр хүлээн зөвшөөрсөн дүнгүүд.
  - (д) Нийлүүлэх өдрөөр уг нэгдэгч үйл ажиллагаа тус бүрийн бүртгэсэн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд хийсэн дараах тохируулга:
    - (i) Нэгдэгч үйл ажиллагаануудын хооронд хийгдсэн ажил гүйлгээнүүдийн үр нөлөөг 22-р параграфын дагуу устгаж цэвэрлэх; ба
    - (ii) Үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой 27-р параграфын дагуу нийцүүлэх.
  - (е) Цэвэр хөрөнгө/өмчийн шинжилгээ, үүн дотроо тусад нь толилуулсан аливаа бүрэлдэхүүн хэсгүүд ба 37-38-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн, дахин үнэлгээний нэмэгдэл эсвэл бууралт гэх мэт аливаа томоохон тохируулга.
  - (ж) Хэрэв үр дүнгийн байгууллага нь нийлүүлэх өдрөөс өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайланг 52-р параграфын дагуу толилуулах сонголт хийсэн бол тус байгууллага нь нэгдэгч үйл ажиллагаа нэг бүрийн хувьд дараах мэдээллийг тодруулна:
    - (i) Өмнөх тайлант үе (үеүд)-ийн эцсээрх санхүүгийн байдлын тайлан;
    - (ii) Өмнөх тайлант үе (үеүд)-ийн санхүүгийн үр дүнгийн тайлан;
    - (iii) Өмнөх тайлант үе (үеүд)-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан;
    - (iv) Өмнөх тайлант үе (үеүд)-ийн мөнгөн гүйлгээний тайлан;
    - (v) Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба бусад тайлбар мэдээллээс бүрдэх тодруулга.
- Үр дүнгийн байгууллага нь энэхүү мэдээллийг дахин тайлагнахгүй боловч нэгдэгч үйл ажиллагаануудын санхүүгийн тайланд ашигласантай ижил сууриар уг мэдээллийг тодруулна. Үр дүнгийн байгууллага нь энэхүү мэдээллийг толилуулсан сууриа тодруулна.
- (и) Үр дүнгийн байгууллагын санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн өдрөөрх тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын аль нэгний хамгийн сүүлийн тайлагналын өдөр нь уг нийлүүлэх өдрийн яг өмнөх өдөр биш байвал уг үр дүнгийн байгууллага нь дараах мэдээллийг тодруулна:
    - (i) Нэгдэгч үйл ажиллагаануудын хамгийн сүүлийн тайлагналын өдрөөс уг нийлүүлэх өдөр хүртэлх хугацаанд хамаарах тэдгээр нэгдэгч үйл ажиллагаа нэг бүрийн орлого, зардал, ашиг, алдагдлын дүнгүүд. Орлогын дүнгүүдийг УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-ын 108-р параграфт заасанчлан, тухайн байгууллагын үйл ажиллагааны хувьд

тохиромжтой арга маягаар шинжилнэ. Үнэн зөв толилуулга болон илүү хамааралтай мэдээллээр хангахын тулд зардлын шинж төрөлд эсвэл тухайн байгууллагын чиг үүргийн аль нэгэнд үндэслэсэн ангиллыг ашигласнаар зардлын дүнгүүдийг УСНББОУС 1-ийн 109-р параграфын дагуу шинжилнэ.

- (ii) Хөрөнгө, өр төлбөрийн гол анги тус бүрийн хувьд уг нийлүүлэх өдрийн яг өмнөх байдлаар тухайн нэгдэгч үйл ажиллагаа нэг бүрийн тайлагнасан дүнгүүд.
- (iii) Уг нийлүүлэх өдрийн яг өмнөх байдлаар тухайн нэгдэгч үйл ажиллагаа нэг бүрийн цэвэр хөрөнгө/өмчид тайлагнасан дүнгүүд.

Үр дүнгийн байгууллага нь уг нийлүүлэх өдрөөс өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайланг дээрх (ж) заалтад заасны дагуу толилуулах сонголт хийсэн тохиолдолд энэхүү мэдээллийг тодруулах шаардлагагүй юм.

55. **Үр дүнгийн байгууллага нь тухайн тайлант үед эсвэл өмнөх тайлант үеүдэд гарч тохиолдсон нийлүүлэлттэй холбоотойгоор уг тайлант үед хүлээн зөвшөөрсөн тохируулгын санхүүгийн үр нөлөөг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна.**

56. 55-р параграфт дурдсан зорилгыг биелүүлэхийн тулд үр дүнгийн байгууллага нь дараах мэдээллийг тодруулна:

- (a) Нийлүүлэлтийн анхны тайлагнал нь тодорхой хөрөнгө, өр төлбөрийн хувьд хараахан дуусаагүй байгаа (40-р параграфыг үзнэ үү) бөгөөд иймээс тухайн нийлүүлэлттэй холбоотойгоор санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг зөвхөн нөхцөлт байдлаар тодорхойлсон бол:
  - (i) Нийлүүлэлтийн анхны тайлагнал нь яагаад иж бүрэн бус байгаа талаархи шалтгаан;
  - (ii) Анхны тайлагнал нь иж бүрэн бус байгаа тэдгээр хөрөнгө, өр төлбөр; ба
  - (iii) Тухайн тайлант үеийн туршид 43-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн, хэмжилтийн хугацааны аливаа тохируулгын шинж төрөл ба дүн.
- (б) Төлөх ёстой татварыг уг нийлүүлэлтийн нөхцлүүдийн үр дүнд чөлөөлсөн бол (33-34-р параграфыг үзнэ үү):
  - (i) Чөлөөлсөн татварын дүн; ба
  - (ii) Уг үр дүнгийн байгууллага нь өөрөө татварын эрх бүхий байгууллага бол татварын авлагад хийсэн залруулгын дэлгэрэнгүй мэдээлэл.

57. Энэ болон бусад УСНББОУС-уудаар шаардсан тусгай тодруулга нь 53 ба 55-р параграфт заасан зорилтуудыг хангахгүй бол уг үр дүнгийн байгууллага нь тэдгээр зорилтуудыг биелүүлэхэд шаардлагатай аливаа нэмэлт мэдээллийг тодруулна.

### **Худалдан авалтын тайлагнал**

58. **Нэгтгэгч нь худалдан авалт нэг бүрийг худалдан авалтын тайлагналын аргыг ашигласнаар тайлагнана.**

### **Худалдан авалтын тайлагналын арга**

59. Худалдан авалтын аргыг ашиглахдаа дараах зүйлсийг гүйцэтгэхийг шаарддаг:
- (а) Нэгтгэгчийг тодорхойлох;
  - (б) Худалдан авалтын өдрийг тодорхойлох;
  - (в) Олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон уг худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба хэмжих;
  - (г) Худалдан авалтаас үүссэн гүүдвил болон олж, гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих.

### **Нэгтгэгчийг тодорхойлох**

60. **Худалдан авалт тус бүрийн хувьд, нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан, тухайн нэгдлийн оролцогч талыг нэгтгэгч гэж тодорхойлно.**
61. Улсын секторын нэгдлийн ангиллыг 7, 8, МЗУ10-МЗУ18-р параграфын дагуу тодорхойлох тохиолдолд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан, тухайн нэгдлийн оролцогч талыг тогтооно.

### **Худалдан авалтын өдрийг тодорхойлох**

62. **Нэгтгэгч нь худалдан авалтын өдрийг тогтооно. Энэ нь худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг олж авсан өдөр юм.**
63. Худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг нэгтгэгч олж авсан өдөр нь ерөнхийдөө уг нэгтгэгч төлбөрийг хууль ёсоор шилжүүлж, тухайн үйл ажиллагааны хөрөнгийг олж эзэмшсэн ба өр төлбөрийг хариуцсан өдөр буюу хаалтын өдөр байдаг. Гэхдээ нэгтгэгч нь хаалтын өдрөөс өмнө эсвэл дараа хяналтыг олж авч болох юм. Жишээлбэл; нэгтгэгч нь тухайн худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг хаалтын өдрөөс өмнө олж авахаар бичгээр үйлдсэн хэлцэлд заасан бол худалдан авалтын өдөр нь хаалтын өдрөөс өмнө байна. Худалдан авалтын өдрийг тодорхойлохдоо, нэгтгэгч нь холбогдох бүх баримт материал, нөхцөл байдлуудыг харгалзан үзнэ.

**Тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон нэгдэгч үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог хүлээн зөвшөөрөх ба хэмжих**

*Хүлээн зөвшөөрөлтийн зарчим*

64. **Худалдан авалтын өдрөөр нэгтгэгч нь олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог гүүдвилээс тусад нь хүлээн зөвшөөрнө. Олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт нь 65, 66-р параграфт тусгайлан заасан нөхцлүүдэд хамаарна.**

*Хүлээн зөвшөөрөлтийн нөхцлүүд*

65. Худалдан авалтын аргыг хэрэглэх үйл явцын нэг хэсэг болох хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг ханган биелүүлэхийн тулд тухайн худалдан авч эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөр нь *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал*-д заасан хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолтыг уг худалдан авалтын өдөр хангасан байх бөгөөд чанарын шинжүүдийг бүрдүүлэх тийм арга замаар хэмжих боломжтой ба нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын мэдээллийн хязгаарлагдмал талуудыг харгалзсан байх ёстой. Тухайлбал; худалдан авсан үйл ажиллагааг зогсоох, ажилтнуудын ажил эрхлэлтийг дуусгавар болгох буюу ажилтнуудыг өөр ажилд шилжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд ирээдүйд нэгтгэгчийн гаргахаар хүлээж байгаа боловч заавал гаргах үүрэг хүлээгээгүй зардал нь тухайн худалдан авалтын өдөр өр төлбөр биш байдаг. Иймээс нэгтгэгч нь эдгээр зардлыг худалдан авалтын аргыг хэрэглэх үйл явцын нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрөхгүй. Харин нэгтгэгч нь эдгээр зардлыг нэгдлийн дараах санхүүгийн тайландаа бусад холбогдох УСНББОУС-уудын дагуу хүлээн зөвшөөрнө.

66. Түүнчлэн, худалдан авалтын аргыг хэрэглэх үйл явцын нэг хэсэг болох хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг ханган биелүүлэхийн тулд тухайн худалдан авч эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөр нь тусдаа ажил гүйлгээний үр дүн биш, харин худалдан авалтын ажил гүйлгээгээр нэгтгэгч ба худалдан авсан үйл ажиллагааны (буюу түүний хуучин эздийн) арилжсан зүйлсийн нэг хэсэг байх ёстой. Олж эзэмшсэн хөрөнгө буюу хариуцсан өр төлбөрийн аль нь худалдан авсан үйл ажиллагааны хувьд арилжааны нэг хэсэг болох, түүнчлэн хэрэв байгаа бол аль нь өөрсдийн шинж төрөл ба холбогдох УСНББОУС-уудын дагуу тайлагнавал зохих тусдаа ажил гүйлгээний үр дүн эсэхийг тодорхойлохын тулд нэгтгэгч нь 109-111-р параграфт дурдсан, заавар удирдамжийг мөрдөнө.

67. Хүлээн зөвшөөрөлтийн зарчим ба нөхцлүүдийг тухайн нэгтгэгч даган мөрдөх нь уг худалдан авсан үйл ажиллагаа өөрийн санхүүгийн тайландаа өмнө нь хөрөнгө, өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөөгүй байсан зарим

хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхөд хүргэж болох юм. Жишээлбэл; худалдан авсан үйл ажиллагаа нь дотооддоо хөгжүүлэн гаргасан бөгөөд холбогдох өртгийг зардалд шингээсэн учраас өөрийн санхүүгийн тайландаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөггүй патент, үйлчлүүлэгчтэй тогтоосон харилцаа гэх мэт тухайн олж эзэмшсэн биет бус хөрөнгүүдийг нэгтгэгч нь хүлээн зөвшөөрнө.

68. Үйл ажиллагааны түрээс ба биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөх талаархи заавар удирдамжийг МЗУ72-МЗУ84-р параграфт заасан. Хүлээн зөвшөөрөлтийн зарчим болон нөхцлүүдийн хувьд хязгаарлагдмал гажих нөхцлийг энэхүү Стандартаар олгодог тийм зүйлсийг өөртөө агуулсан тодорхойлогдох хөрөнгө ба өр төлбөрийн төрлүүдийг 76-82-р параграфт тусгайлан заасан.

Худалдан авалтаар олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн ангилал буюу сонголт

69. **Тухайн олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийг нэгтгэгч нь бусад УСНББОУС-уудыг дараагийн тайлант үед даган мөрдөх зорилгоор уг худалдан авалтын өдрөөр ангилах буюу сонгоно. Нэгтгэгч нь уг худалдан авалтын өдрөөр оршин байсан заавал биелүүлэх хэлцлийн нөхцөл (үүн дотроо гэрээний нөхцөл), эдийн засгийн нөхцөл байдал, өөрийн үйл ажиллагааны буюу нягтлан бодох бүртгэлийн бодлого, бусад холбогдох нөхцлүүдэд үндэслэн ийм ангилал буюу сонголтыг хийнэ.**

70. Зарим тохиолдолд УСНББОУС-ууд нь тухайн тодорхой хөрөнгө буюу өр төлбөрийг байгууллага хэрхэн ангилдаг буюу сонгодог эсэхээс хамааран өөр байдлаар тайлагнахаар заасан байдаг. Нэгтгэгч нь уг худалдан авалтын өдрөөр оршин байсан холбогдох нөхцлүүдэд үндэслэн хийх ангилал буюу тодорхойлолтын жишээнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) УСНББОУС 29-ийн дагуу бодит үнэ цэнээр эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжсэн гэж ангилсан тухайн тодорхой санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн ангилал;
- (б) Үүсмэл хэрэглүүрийг УСНББОУС 29-ийн дагуу хейжийн хэрэглүүр гэж ангилах сонголт; ба
- (в) Дагалдах үүсмэл хэрэглүүрийг УСНББОУС 29-ийн дагуу үндсэн гэрээнээс салган тусгаарлах хэрэгтэй эсэх үнэлгээ (уг нэр томъёог энэ Стандартад ашиглах үед энэ нь “ангилал”-д хамаарах асуудал байна).

71. Энэ Стандарт нь 69-р параграфт заасан зарчмаас гажих дараах хоёр нөхцлийг заасан:

- (а) Түрээсийн гэрээг УСНББОУС 13, Түрээс-ийн дагуу үйл ажиллагааны түрээс эсвэл санхүүгийн түрээс гэж ангилах; ба

- (б) Даатгалын гэрээг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу уг гэрээг даатгалын гэрээ гэж ангилах.

Нэгтгэгч нь тухайн заавал биелүүлэх хэлцлийн эхэн дэх (хэрэв заавал биелүүлэх хэлцлийн нөхцөл нь түүний ангиллыг өөрчлөхөд хүргэх тийм байдлаар өөрчлөгдсөн бол тухайн засвар өөрчлөлтийн өдрөөрх, магадгүй худалдан авалтын өдрөөрх) гэрээний нөхцлүүд болон бусад хүчин зүйлсэд үндэслэн тэдгээр заавал биелүүлэх хэлцлийг ангилна.

*Хэмжилтийн зарчим*

72. **Нэгтгэгч нь тухайн олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийг тэдгээрийн худалдан авалтын өдрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.**

73. Худалдан авалт тус бүрийн хувьд, нэгтгэгч нь түүний одоогийн өмчлөлийн хувь оролцоог илэрхийлэх бөгөөд тухайн байгууллагыг татан буулгах тохиолдолд түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн авах эрхийг эзэмшигчдээ олгодог, уг худалдан авсан үйл ажиллагаан дахь хяналтын бус хувь оролцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг тэрхүү худалдан авалтын өдөр дараах дүнгийн аль нэгээр хэмжинэ:

(а) Бодит үнэ цэнэ; эсвэл

(б) Одоогийн өмчлөлийн хэрэглүүр нь тухайн худалдан авсан үйл ажиллаганы тодорхойлогдох цэвэр хөрөнгийн хүлээн зөвшөөрсөн дүнд эзлэх хувь тэнцүүлсэн хэмжээ.

УСНББОУС-уудаар хэмжилтийн өөр суурийг шаардсанаас бусад тохиолдолд хяналтын бус хувь оролцооны бусад бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг тэдгээрийн уг худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ.

74. Хэмжилтийн зарчмын хувьд хязгаарлагдмал гажих нөхцлийг энэ Стандартаар олгодог тийм зүйлсийг өөртөө агуулсан тухайн тодорхойлогдох хөрөнгө болон өр төлбөрийн төрлүүдийг 78–84-р параграфт тусгайлан заасан байдаг.

*Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн зарчмын гажих нөхцлүүд*

75. Энэ Стандартад түүний хүлээн зөвшөөрөлтийн буюу хэмжилтийн зарчмуудын хязгаарлагдмал гажих нөхцлүүдийг заасан байдаг. Гажих нөхцлүүдийг хэрэглэх тухайн тодорхой зүйлс болон тэдгээр гажих нөхцлүүдийн шинж төрлийг 76–84-р параграфт тусгайлан заасан. Нэгтгэгч нь 76–84-р параграфын шаардлагуудыг мөрдсөнөөр тэдгээр зүйлсийг тайлагнах бөгөөд ингэснээр зарим зүйлсийг дараах байдлаар тусгахад хүргэдэг:

(а) 65-66-р параграфт заасан нөхцлүүдээс гадна хүлээн зөвшөөрөлтийн нөхцлийг даган мөрдснөөр, эсвэл уг хүлээн зөвшөөрөлтийн зарчим

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

ба нөхцлүүдийг мөрдснөөс өөр үр дүн бүхий бусад УСНББОУС-уудын шаардлагуудыг даган мөрдснөөр хүлээн зөвшөөрөх.

- (б) Тэдгээрийн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнээс өөр дүнгээр хэмжих.

Хүлээн зөвшөөрөлтийн зарчмын гажих нөхцөл

Болзошгүй өр төлбөр

76. УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө* нь болзошгүй өр төлбөрийг дараах байдлаар тодорхойлдог:

- (а) Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг бөгөөд түүний оршин байдал нь бүхэлдээ уг байгууллагын хянах боломжгүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын тохиолдолд эсвэл үл тохиолдолтоор зөвхөн батлагдах, боломжит үүрэг; эсвэл
- (б) Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг боловч дараах шалтгааны улмаас хүлээн зөвшөөрөөгүй одоогийн үүрэг:
- (i) Уг үүргийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлалгүй; эсвэл
- (ii) Үүргийн дүнг хангалттай найдвартайгаар хэмжих боломжгүй.

77. Уг худалдан авалтын өдрөөр ямар болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 19-ийн шаардлагуудыг даган мөрдөхгүй. Харин худалдан авалтын үр дүнд хариуцсан болзошгүй өр төлбөр нь өнгөрсөн үйл явдлаас үүссэн одоогийн үүрэг бөгөөд түүний бодит үнэ цэнийг найдвартай<sup>1</sup> хэмжих боломжтой бол нэгтгэгч нь уг болзошгүй өр төлбөрийг тухайн худалдан авалтын өдрөөр хүлээн зөвшөөрнө. Иймээс УСНББОУС 19-ийн эсрэгээр буюу уг үүргийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлалгүй байлаа ч гэсэн нэгтгэгч нь худалдан авалтын үр дүнд хариуцсан болзошгүй өр төлбөрийг тухайн худалдан авалтын өдрөөр хүлээн зөвшөөрнө. Болзошгүй өр төлбөрийн дараагийн тайлант үеийн тайлагналын талаархи заавар удирдамжийг 115-р параграфт тусгасан.

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн зарчмыг нэгэн зэрэг гажих нөхцлүүд

Орлогын албан татвар (Худалдан авалтын нөхцөлд тусгагдсан тохиолдолд)

78. Улсын секторын байгууллагын хийсэн худалдан авалт нь тухайн төлөх ёстой татварыг уг худалдан авалтын нөхцлийн нэг хэсэг байдлаар татварын эрх бүхий байгууллагаас чөлөөлөхөд хүргэж болох юм. Нэгтгэгч нь уг худалдан авалтын нөхцлийн үр дүн байдлаар чөлөөлөгдсөн аливаа

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

татвар ногдох зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй (холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ85-МЗУ87-р параграфт тусгасан).

79. Нэгтгэгч нь худалдан авалтанд тусган оруулсан буюу түүнээс үүссэн аливаа үлдсэн татвар ногдох зүйлсийг орлогын албан татварыг зохицуулдаг, нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ. Нэгтгэгч нь худалдан авалтанд тусган оруулсан буюу түүнээс үүссэн аливаа үлдсэн орлогыг УСНББОУС 23-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ.

#### Ажилтны тэтгэмж

80. Нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааны ажилтны тэтгэмжийн хэлцэлтэй холбоотой өр төлбөр (хэрэв байгаа бол хөрөнгө)-ийг УСНББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ.

#### Нөхөн төлбөрийн хөрөнгө

81. Худалдан авалтанд хамаарах борлуулагч нь тодорхой хөрөнгө, өр төлбөрийн бүх эсвэл зарим хэсэгтэй холбоотой болзошгүй буюу тодорхой бус зүйлийн үр дагаврын хувьд нэгтгэгчид гэрээний дагуу нөхөн төлбөр төлж болох юм. Тухайлбал; борлуулагч нь тухайн болзошгүй зүйлээс үүсэх өр төлбөрийн хувьд тогтоосон дүнгээс илүү гарсан алдагдлын хувьд нэгтгэгчид нөхөн төлж болох билээ; өөрөөр хэлбэл, борлуулагч нь нэгтгэгчийн өр төлбөр тогтоосон дүнгээс хэтрэхгүй гэсэн баталгаа гаргадаг. Үүний үр дүнд нэгтгэгч нь нөхөн төлбөрийн хөрөнгийг хүлээн авдаг. Нэгтгэгч нь тухайн нөхөн төлөгдөж буй зүйлтэй ижил хугацаанд уг нөхөн төлбөрийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх бөгөөд тэрхүү нөхөн төлөгдөж буй зүйлийн үнэлгээтэй ижил сууриар уг хөрөнгийн үнэлгээг хийх ёстой. Иймээс нөхөн төлбөр нь худалдан авалтын өдрөөр хүлээн зөвшөөрсөн бөгөөд уг худалдан авалтын өдрөөрх түүний бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө буюу өр төлбөртэй холбоотой бол нэгтгэгч нь тэрхүү худалдан авалтын өдрөөр түүний бодит үнэ цэнээр хэмжсэн нөхөн төлбөрийн хөрөнгийг тухайн худалдан авалтын өдөр хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнээр хэмжсэн нөхөн төлбөрийн хөрөнгийн хувьд, тухайн цуглуулагдах боломжит байдлаас хамаарсан ирээдүйн мөнгөн гүйлгээний тодорхой бус байдлын үр нөлөөг уг бодит үнэ цэнийн хэмжилтэнд тусган оруулах бөгөөд үнэлгээний тусдаа хасагдуулга шаардлагагүй юм (холбогдох заавар удирдамжийг МЗУ88-р параграфт заасан).
82. Зарим тохиолдолд нөхөн төлбөр нь хүлээн зөвшөөрөлтийн буюу хэмжилтийн зарчмуудын гажих нөхцөлд хамаарах хөрөнгө, өр төлбөртэй холбоотой байж болно. Жишээлбэл; нөхөн төлбөр нь худалдан авалтын өдөр бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүйн улмаас тухайн өдөр хүлээн зөвшөөрөөгүй, болзошгүй өр төлбөртэй холбоотой байж болох юм. Нөгөө талаас, нөхөн төлбөр нь худалдан авалтын өдрийн бодит үнэ цэнээс өөр сууриар хэмждэг, тухайлбал, ажилтны тэтгэмжээс үүссэн хөрөнгө буюу өр төлбөртэй холбоотой байж болно. Ийм тохиолдолд уг нөхөн төлсөн зүйлийг хэмжихэд ашигласан таамаглалтай нийцэх



## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

таамаглалыг ашигласнаар тухайн нөхөн төлбөрийн хөрөнгийг хүлээн зөвшөөрч, хэмжих бөгөөд энэ нь тэрхүү нөхөн төлбөрийн хөрөнгийн цуглуулагдах байдлын талаархи удирдлагын үнэлгээ болон нөхөн төлсөн дүнгийн талаархи гэрээний аливаа хязгаарлалтуудад хамаарна. Нөхөн төлбөрийн хөрөнгийг дараагийн тайлант үед тайлагнах талаархи заавар удирдамжийг 116-р параграфт тусгасан.

Хэмжилтийн зарчмын гажих нөхцөл

Дахин олж эзэмшсэн эрх

83. Зах зээлийн оролцогч нар нь бодит үнэ цэнийг хэмжихдээ заавал биелүүлэх хэлцлийн боломжит шинэчлэл, сунгалтыг харгалзан үздэг эсэхээс үл хамааран нэгтгэгч нь уг холбогдох заавал биелүүлэх хэлцлийн үлдсэн хугацаанд үндэслэн биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн тухайн дахин олж эзэмшсэн эрхийн үнэ цэнийг хэмжинэ. Холбогдох заавар удирдамжийг МЗУ79-МЗУ80-р параграфт тусгасан.

Хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээ

84. Нэгтгэгч нь худалдан авсан үйл ажиллагааны хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээ буюу уг худалдан авсан үйл ажиллагааны хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээг нэгтгэгчийн хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээ болгон сольж орлуулахтай холбоотой өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүрийг тухайн худалдан авалтын өдөр хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу хэмжинэ.

**Тохиролцоот худалдан авалтаас үүсэх гүүдвил буюу олзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих**

85. Нэгтгэгч нь доорх (б)-д дурдсан дүнгээс (а)-д дурдсан дүнгийн давж гарсан илүү зөрүүгээр гүүдвیلیйг тухайн худалдан авалтын өдөр хэмжиж, хүлээн зөвшөөрөх бөгөөд 86-р параграфын шаардлагуудад захирагдана:

(а) Дараах зүйлсийн нийлбэр:

- (i) Энэ Стандартын дагуу хэмжсэн тухайн шилжүүлсэн төлбөр, тэрхүү төлбөр нь ерөнхийдөө уг худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ байхыг шаарддаг (95-р параграфыг үзнэ үү);
- (ii) Энэ Стандартын дагуу хэмжсэн, уг худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцооны дүн; ба
- (iii) Үе шаттайгаар хүрсэн худалдан авалтын тохиолдолд (99-100-р параграфыг үзнэ үү), уг худалдан авсан үйл ажиллагааны хувьд нэгтгэгчийн өмнө эзэмшиж байсан

**өмчийн хувь оролцооны тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ.**

(б) Энэ Стандартын дагуу хэмжсэн, уг олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн тухайн худалдан авалтын өдрөөрх цэвэр дүн.

86. Худалдан авалт нь дараах үр дүнтэй байх зөвхөн тэр хэмжээгээр нэгтгэгч нь гүүдвилийг хүлээн зөвшөөрнө:

(а) Мөнгөн орлогын гүйлгээ бий болгох (мөнгө бий болгогч үйл ажиллагааны худалдан авалт гэх мэт); ба/буюу

(б) Нэгтгэгчийн цэвэр мөнгөн зарлагын гүйлгээний бууралт.

**Нэгтгэгч нь дээрх 85-р параграфын (б)-д дурдсан дүнгээс (а)-д дурдсан дүнгийн давж гарсан аливаа цаашдын зөрүүг ашиг, алдагдалд гарз гэж хүлээн зөвшөөрнө.**

87. Нэгтгэгч ба худалдан авсан үйл ажиллагаа (буюу түүний хуучин эзэд) нь зөвхөн өмчийн хувь оролцоогоо солилцдог худалдан авалтын хувьд, худалдан авалтын өдрөөрх уг худалдан авсан үйл ажиллагааны өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнэ нь тухайн худалдан авалтын өдрөөрх нэгтгэгчийн өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнээс илүү найдвартайгаар хэмжигдэх боломжтой байж болох юм. Ийм тохиолдолд нэгтгэгч нь шилжүүлсэн өөрийн өмчийн хувь оролцооны тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг биш, харин уг худалдан авалтын өдрөөрх тэрхүү худалдан авсан үйл ажиллагааны өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнийг ашигласнаар гүүдвилийн дүнг тодорхойлно. Төлбөр шилжүүлдэггүй худалдан авалтын хувьд гүүдвилийн дүнг тодорхойлохын тулд нэгтгэгч нь тухайн шилжүүлэх төлбөрийн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийн оронд уг худалдан авсан үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцооны тэрхүү худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг ашиглана (85(а)(i) параграфыг үзнэ үү). Холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ94-р параграфт тусгасан.

*Тохиролцоот худалдан авалт*

88. 85(б) параграфт дурдсан дүн нь 85(а) параграфт тусгайлан заасан дүнгүүдийн нийлбэрээс давж илүү гарах худалдан авалт болох тийм тохиролцоот худалдан авалтыг нэгтгэгч нь улсын секторт зарим үед хийдэг бөгөөд худалдан авалт гэж ангилдаг. 90-р параграфын шаардлагуудыг мөрдсөний дараа ийм илүү дүн үлддэг бол нэгтгэгч нь үр дүн болох олзыг тухайн худалдан авалтын өдөр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Олз нь уг нэгтгэгчид хамаарах юм.

89. Тухайлбал, борлуулагч нь эдийн засгийн албадлага шахалтанд буй албадан борлуулалт болох тийм худалдан авалтын хувьд тохиролцоот худалдан авалт хийгдэж болох юм. Гэвч 76-84-р параграфт авч хэлэлцсэн тухайн тодорхой зүйлсэд хамаарах хүлээн зөвшөөрөлтийн буюу хэмжилтийн гажих нөхцлүүд нь тохиролцоот худалдан авалтаар мөн олз

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

хүлээн зөвшөөрөхөд (эсвэл хүлээн зөвшөөрсөн олзын дүнг өөрчлөхөд) хүргэж болох юм.

90. Тохиролцоот худалдан авалтын олзыг хүлээн зөвшөөрөхийн өмнө нэгтгэгч нь уг олж эзэмшсэн бүх хөрөнгө ба хариуцсан бүх өр төлбөрөө зөв тодорхойлсон эсэхийг дахин үнэлэх бөгөөд тэрхүү хяналт үнэлгээгээр тогтоосон аливаа нэмэлт хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүний дараа, нэгтгэгч нь тухайн худалдан авалтын өдөр хүлээн зөвшөөрөхийг энэ Стандартаар шаарддаг доорх бүх зүйлсийн дүнг хэмжихдээ ашигласан горимуудыг нягталж шалгана:
- (а) Олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөр;
  - (б) Хэрэв байгаа бол тухайн худалдан авсан үйл ажиллагаан дахь хяналтын бус хувь оролцоо;
  - (в) Үе шаттайгаар хүрсэн худалдан авалтын хувьд, уг худалдан авсан үйл ажиллагаанд тэрхүү нэгтгэгчийн өмнө эзэмшиж байсан өмчийн хувь оролцоо; ба
  - (г) Шилжүүлсэн төлбөр.

Ийм нягтлах шалгалтын зорилго нь тухайн худалдан авалтын өдрөөр бэлэн, боломжтой байгаа бүх мэдээллийн үр нөлөөг удирдлага зохих ёсоор тусгасан эсэхийг магадлах явдал юм.

91. Улсын секторын хувьд байгууллага нь тухайн худалдан авсан үйл ажиллагааны бодит үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү биш төлбөрийг шилжүүлэх арилжааны бус ажил гүйлгээгээр уг үйл ажиллагааны хяналтыг зарим үед олж авдаг. Ийм нөхцөл байдалд доорх зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
- (а) Үйл ажиллагаанууд буюу байгууллагуудыг нөхөн төлбөртэйгээр битүүмжлэн хураах; ба
  - (б) Донор байгууллагаас нэрлэсэн багахан төлбөртэйгээр үйл ажиллагааг уг нэгтгэгчид шилжүүлэх.

92. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанар нь худалдан авалтын шинж чанартай байх тохиолдолд ийм арилжааны бус худалдан авалтыг тохиролцоот худалдан авалт гэж үзэх бөгөөд 88-90-р параграфын дагуу тайлагнана.

*Төлбөр шилжүүлээгүй хийгдсэн арилжааны бус худалдан авалт*

93. Улсын секторын хувьд байгууллага нь төлбөр шилжүүлэхгүй арилжааны бус ажил гүйлгээгээр үйл ажиллагааны хяналтыг зарим үед олж авдаг. Ийм нөхцөл байдалд доорх зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
- (а) Үйл ажиллагаанууд буюу байгууллагуудыг нөхөн төлбөргүйгээр битүүмжлэн хураах (үүнийг мөн албадлагаар төрийн мэдэлд авах гэж нэрлэдэг).

(б) Донор байгууллагаас төлбөргүйгээр үйл ажиллагааг тухайн байгууллагад шилжүүлэх. Ийм шилжүүлэг нь өв залгамжлалын хэлбэртэй байж болно.

ба

(в) Үйл ажиллагаа нь цэвэр өр төлбөртэй байх тохиолдолд түүнийг уг байгууллагад шилжүүлэх. Тухайн байгууллага нь уг үйл ажиллагааг зогсоохоос сэргийлэхийн тулд цэвэр өр төлбөрийг шилжүүлэн авахыг зөвшөөрч болох юм. Ийм ажил гүйлгээг зарим үед “авралын арга хэмжээ” гэж нэрлэдэг.

94. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанар нь худалдан авалтын шинж чанартай байх тохиолдолд төлбөр шилжүүлэхгүй ийм арилжааны бус ажил гүйлгээгээр уг худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг олж авсан нэгтгэгч нь гүүдвил хүлээн зөвшөөрөхгүй. Тухайн нэгтгэгч нь олз, гарзыг 86-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

#### *Шилжүүлсэн төлбөр*

95. Худалдан авалтаар шилжүүлсэн төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжинэ. Нэгтгэгчийн шилжүүлсэн хөрөнгүүдийн тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ, худалдан авсан үйл ажиллагааны хуучин эздэд уг нэгтгэгчийн төлөх өр төлбөр, нэгтгэгчийн гарган өгсөн өмчийн хувь оролцооны нийлбэрээр тэрхүү бодит үнэ цэнийг тооцоолдог. (Гэвч худалдан авсан үйл ажиллагааны ажилтнуудын эзэмшиж байсан урамшууллын хариуд солилцон олгож байгаа бөгөөд тухайн худалдан авалтаар шилжүүлсэн төлбөрт багтсан, уг нэгтгэгчийн хувьцаанд суурилсан төлбөр хэлбэртэй байх аливаа урамшууллын хэсгийг бодит үнэ цэнээр биш, харин 84-р параграфын дагуу хэмжинэ.) Төлбөрийн боломжит хэлбэрүүдийн жишээнд дараах зүйлс хамаарна: мөнгө, бусад хөрөнгө, үйл ажиллагаа буюу нэгтгэгчийн хяналтанд буй байгууллага, болзошгүй төлбөр, энгийн буюу давуу эрхтэй өмчийн хэрэглүүр, опцион, баталгаа, хамтын байгууллагын гишүүний хувь оролцоо.

96. Шилжүүлсэн төлбөр нь нэгтгэгчийн хөрөнгө болон өр төлбөрийг агуулах бөгөөд тэдгээрийн дансны үнэ нь тухайн худалдан авалтын өдрөөрх өөрсдийн бодит үнэ цэнээсээ өөр байж болох юм (жишээлбэл; нэгтгэгчийн мөнгөн зүйлсийн бус хөрөнгө эсвэл үйл ажиллагаа). Ийм тохиолдолд нэгтгэгч нь уг шилжүүлсэн хөрөнгө, өр төлбөрийг тухайн худалдан авалтын өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр дахин хэмжих ба үр дүн болох аливаа олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Гэвч зарим тохиолдолд, шилжүүлсэн хөрөнгө, өр төлбөр нь (жишээлбэл; хөрөнгө, өр төлбөрийг хуучин эздэд биш, харин тухайн худалдан авсан үйл ажиллагаанд шилжүүлсэн тул) тэрхүү худалдан авалтын дараах нэгдсэн байгууллагад үлдэх ба иймээс нэгтгэгч нь тэдгээрийн хяналтыг хадгалж үлддэг. Энэ тохиолдолд, нэгтгэгч нь тэдгээр хөрөнгө, өр төлбөрийг худалдан авалтын өдрийн яг өмнөх дансны үнээр хэмжих бөгөөд худалдан авалтын өмнө ба дараа өөрийн хянадаг хөрөнгө, өр төлбөрийн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхгүй.

Болзошгүй төлбөр

97. Тухайн худалдан авсан үйл ажиллагааны хариуд нэгтгэгчийн шилжүүлсэн төлбөр нь болзошгүй төлбөрийн хэлцлийн үр дүн болох аливаа хөрөнгө, өр төлбөрийг багтаасан байна (95-р параграфыг үзнэ үү). Нэгтгэгч нь тухайн худалдан авалтын өдрөөрх болзошгүй төлбөрийн бодит үнэ цэнийг уг худалдан авсан үйл ажиллагааны хариуд шилжүүлсэн төлбөрийн нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрнө.
98. Нэгтгэгч нь санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангадаг, болзошгүй төлбөр төлөх өөрийн үүргийг УСНББОУС 28-ын 9-р параграфт заасан өмчийн хэрэглүүр ба санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтонд үндэслэн, санхүүгийн өр төлбөр эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг байдлаар ангилна. Хэрэв тохиролцсон нөхцлүүд хангагдвал уг өмнө шилжүүлсэн төлбөрийг буцаах эрхийг нэгтгэгч нь хөрөнгө гэж ангилна. Болзошгүй төлбөрийн дараагийн тайлант үеийн тайлагналын талаархи заавар удирдамжийг 117-р параграфт тусгасан.

**Үе шаттайгаар хийсэн худалдан авалт**

99. Худалдан авалтын өдрөөс яг өмнө өмчийн хувь оролцоог нь эзэмшиж байсан нэгтгэгч нь тэрхүү худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг зарим үед олж авдаг. Жишээлбэл; 20X1 оны 12 дугаар сарын 31-нд А байгууллага нь Б байгууллагын хяналтын бус өмчийн хувь оролцоо буюу өмчийн 35 хувийг эзэмшдэг байсан. Уг өдөр, А байгууллага нь Б байгууллагын өмчийн 40 хувийг нэмж худалдан авснаар Б байгууллагыг хяналтандаа авсан. Ийм ажил гүйлгээг энэ Стандартад “үе шаттайгаар хийсэн худалдан авалт” гэж нэрлэдэг бөгөөд зарим үед мөн “үе шаттай худалдан авалт” гэдэг.
100. Үе шаттайгаар хийсэн худалдан авалтын хувьд, нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааны хувьд өмнө эзэмшиж байсан өөрийн өмчийн хувь оролцоог тухайн худалдан авалтын өдрөөрх түүний бодит үнэ цэнээр дахин хэмжих ба хэрэв байгаа бол үр дүн болох олз, гарзыг ашиг, алдагдал эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн аль тохиромжтойд хүлээн зөвшөөрнө. Худалдан авсан үйл ажиллагаан дахь өөрийн өмчийн хувь оролцооны үнэ цэнийн өөрчлөлтийг нэгтгэгч нь өмнөх тайлант үеүдэд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн байж болох юм. Ийм тохиолдолд уг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн дүнг хэрэв нэгтгэгч нь өмнө эзэмшиж байсан өмчийн хувь оролцоогоо шууд данснаас хассан бол шаардах байсантай ижил сууриар хүлээн зөвшөөрнө.

**Саналын эрхийн өөрчлөлтөөр, зөвхөн гэрээгээр болон төлбөр шилжүүлэхгүйгээр үүнтэй адилтгах нөхцөлд худалдан авалтыг хийсэн тохиолдолд худалдан авалтын аргыг хэрэглэх талаархи нэмэлт заавар удирдамж**

*Саналын эрхийн өөрчлөлтөөр, зөвхөн гэрээгээр болон төлбөрийн шилжүүлэлтгүй үүнтэй адилтгах нөхцөлд хийгдсэн худалдан авалт*

101. Нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг зарим үед төлбөр шилжүүлэхгүйгээр олж авдаг. Худалдан авалтыг тайлагнах уг худалдан авалтын аргыг ийм улсын секторын нэгдлийн хувьд мөрдөнө. Ийм нөхцөл байдалд дараах тохиолдол хамаарна:
- (а) Худалдан авсан үйл ажиллагаа нь хяналтыг олж авахын тулд одоогийн хөрөнгө оруулагч (нэгтгэгч)-аас өөрийн хангалттай тооны өмчийн хувьцааг буцаан худалдан авах.
  - (б) Саналын эрхийн олонхийг эзэмшдэг нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааг хянахад өмнө нь саад учруулж байсан цөөнхийн хязгаарлах эрхийн хугацаа дуусах.
  - (в) Нэгтгэгч ба уг худалдан авсан үйл ажиллагаа нь өөрсдийн үйл ажиллагааг зөвхөн гэрээгээр нэгтгэхийг харилцан зөвшөөрөх. Нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааны хяналтын хариуд ямар нэг төлбөр шилжүүлэхгүй ба тухайн худалдан авалтын өдөр эсвэл түүнээс өмнө тэрхүү худалдан авсан үйл ажиллагааны хувьд өмчийн хувь оролцоог эзэмшихгүй.
102. Зөвхөн гэрээгээр хийгдсэн худалдан авалтын хувьд, нэгтгэгч нь энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрсөн уг худалдан авсан үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн дүнг тэрхүү худалдан авсан үйл ажиллагааны эздэд хамааруулна. Өөрөөр хэлбэл, худалдан авсан үйл ажиллагаан дахь тоогоор илэрхийлж болох өмчийн бүх хувь оролцоо нь хяналтын бус хувь оролцоонд хамаарах үр дүнтэй боловч тухайн худалдан авсан үйл ажиллагааны хувьд нэгтгэгчээс бусад талуудын эзэмшиж буй тоогоор илэрхийлж болох өмчийн хувь оролцоог тэрхүү нэгдлийн дараах уг нэгтгэгчийн санхүүгийн тайланд хяналтын бус хувь оролцоо гэж тусгана.

### **Хэмжилтийн хугацаа**

103. **Худалдан авалтын анхны тайлагнал нь уг худалдан авалт хийгдсэн тайлант үеийн эцэст бүрэн дуусаагүй байсан бол нэгтгэгч нь хараахан тайлагнаж дуусаагүй байгаа зүйлсийн хувьд тооцсон нөхцөлт дүнг өөрийн санхүүгийн тайланд тусгана. Худалдан авалтын өдрөөр оршин байсан бөгөөд хэрэв мэдэгдсэн бол уг өдрөөр хүлээн зөвшөөрсөн дүнгийн хэмжилтэнд нөлөөлөх байсан баримт материал болон нөхцөл байдлын талаар олж авсан шинэ мэдээллийг тусгахын тулд нэгтгэгч нь тэрхүү худалдан авалтын өдөр хүлээн зөвшөөрсөн, нөхцөлт дүнгүүдийг тухайн хэмжилтийн хугацааны туршид буцаах горимоор залруулна. Худалдан авалтын өдрөөр оршин байсан бөгөөд хэрэв мэдэгдсэн бол уг өдрөөрх тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтөнд хүргэх байсан баримт материал болон нөхцөл байдлын талаар шинэ мэдээлэл олж авсан тохиолдолд нэгтгэгч нь тэрхүү нэмэлт хөрөнгө буюу өр төлбөрийг тухайн хэмжилтийн хугацааны туршид мөн хүлээн зөвшөөрнө. Нэгтгэгч нь худалдан авалтын өдрөөр оршин байсан баримт материал ба нөхцөл байдлын талаар эрэлхийлж байсан мэдээллийг хүлээн авсан буюу өөр мэдээлэл олж авах боломжгүй гэдгийг тогтоосноор тухайн**

**хэмжилтийн хугацаа дуусгавар болдог. Гэхдээ хэмжилтийн хугацаа нь тухайн худалдан авалтын өдрөөс хойш нэг жилээс хэтрэхгүй байна.**

104. Хэмжилтийн хугацаа гэдэг нь худалдан авалтын хувьд хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнд уг нэгтгэгч залруулга хийж болох, тухайн худалдан авалтын өдрөөс хойшхи хугацаа юм. Хэмжилтийн хугацаа нь дараах зүйлсийг энэ Стандартын шаардлагуудын дагуу уг худалдан авалтын өдрөөр тодорхойлж, хэмжихэд шаардлагатай мэдээллийг олж авах ул үндэслэлтэй хугацаагаар тэрхүү нэгтгэгчийг хангадаг.
- (a) Олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон уг худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоо;
  - (б) Худалдан авсан үйл ажиллагааны хувьд шилжүүлсэн төлбөр (буюу гүүдвилийг хэмжихэд ашигласан бусад дүн);
  - (в) Үе шаттайгаар хийсэн худалдан авалтын тохиолдолд, уг худалдан авсан үйл ажиллагааны хувьд нэгтгэгчийн өмнө эзэмшиж байсан өмчийн хувь оролцоо; ба
  - (г) Тохиролцоот худалдан авалтаас үүсэх гүүдвил, гарз эсвэл олз.
105. Худалдан авалтын өдрөөс хойш олж авсан мэдээлэл нь уг хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнд залруулга хийхэд хүргэх эсэх эсвэл тухайн мэдээлэл нь худалдан авалтын өдрөөс хойш гарч тохиолдсон үйл явдлын үр дүн эсэхийг тодорхойлохын тулд нэгтгэгч нь холбогдох бүх хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Холбогдох хүчин зүйлс гэдэгт нэмэлт мэдээллийг олж авсан өдөр, нөхцөлт дүнгүүдэд өөрчлөлт оруулсан шалтгааныг тухайн нэгтгэгч тодорхойлж чадах эсэх нь хамаарна. Худалдан авалтын өдрөөс хойш богино хугацааны дотор олж авсан мэдээлэл нь хэдэн сарын дараа олж авсан мэдээлэлтэй харьцуулахад тухайн худалдан авалтын өдрөөр оршин байсан нөхцөл байдлыг тусгах илүү их магадлалтай юм. Жишээлбэл; бодит үнэ цэнийг өөрчилсөн хөндлөнгийн үйл явдлыг олж тогтоосноос бусад тохиолдолд, худалдан авалтын өдрөөр хэмжсэн түүний нөхцөлт бодит үнэ цэнээс эрс өөр дүнгээр хөрөнгийг тухайн худалдан авалтын өдрийн дараахан гуравдагч этгээдэд борлуулах нь тэрхүү нөхцөлт дүн алдаатай байсныг илэрхийлэх магадлалтай юм.
106. Тодорхойлогдох хөрөнгө (өр төлбөр)-ийн хувьд хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнгийн нэмэгдэлтийг (бууралтыг) нэгтгэгч нь гүүдвилийн дүнг бууруулах (нэмэгдүүлэх) замаар хүлээн зөвшөөрнө. Гэвч хэмжилтийн хугацааны туршид олж авсан шинэ мэдээлэл нь зарим үед нэгээс олон хөрөнгө буюу өр төлбөрийн нөхцөлт дүнд залруулга хийхэд хүргэж болох юм. Жишээлбэл; худалдан авсан үйл ажиллагааны хариуцлагын даатгалд бүрэн буюу хэсэгчлэн хамрагдсан, тухайн худалдан авсан үйл ажиллагааны хөрөнгүүдийн аль нэгэнд гарсан эвдрэл гэмтэлтэй холбоотой хохирлыг төлөх үүргийг нэгтгэгч нь хүлээсэн байж болно. Хэрэв нэгтгэгч нь худалдан авалтын өдрөөрх уг үүргийн бодит үнэ цэнийн талаархи мэдээллийг тухайн хэмжилтийн хугацаанд олж авсан бол тэрхүү өр төлбөрийн хувьд хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнгийн өөрчлөлтийн улмаас

гүүдвилд хийгдэх залруулга ба даатгагчаас нэхэмжилсэн авлагын хувьд хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнгийн өөрчлөлтийн үр дүн болох гүүдвилийн харгалзах залруулгыг (бүхэлд нь буюу хэсэгчлэн) харилцан суутгаж, цэвэр дүнгээр тооцно.

107. Худалдан авалтын тайлагналыг тухайн худалдан авалтын өдрөөр бүрэн дуусгасан мэтээр нэгтгэгч нь уг нөхцөлт дүнгийн залруулгыг тэрхүү хэмжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрнө. Иймээс нэгтгэгч нь санхүүгийн тайланд толилуулсан өмнөх тайлант үеүдийн хувьд зэрэгцүүлэгдэх мэдээллийг шаардлагатай хэмжээгээр засварлана, үүнд: анхны тайлагналын үед хүлээн зөвшөөрсөн элэгдэл, хорогдуулга буюу бусад орлогын үр нөлөөний аливаа өөрчлөлтийг тусгана.
108. Хэмжилтийн хугацаа дууссаны дараа, нэгтгэгч нь зөвхөн алдааг засварлахын тулд худалдан авалтын тайлагналыг УСНББОУС 3-ын дагуу засварлан өөрчилнө.

#### **Худалдан авалтын ажил гүйлгээний нэг хэсэг болох эсэхийг тодорхойлох**

109. **Нэгтгэгч ба худалдан авсан үйл ажиллагаа нь уг хаудалдан авалтын яриа хэлцлийг эхлүүлэхээс өмнө, урьдчилан оршин байсан харилцаа буюу бусад хэлцэл тохиролцоотой байж болох юм. Эсвэл тэд яриа хэлцлийн явцад тухайн худалдан авалтаас тусдаа, өөр хэлцэл хийж болно. Аль ч тохиолдолд, нэгтгэгч нь худалдан авалтаар нэгтгэгч ба уг худалдан авсан үйл ажиллагааны (буюу түүний хуучин эздийн) хооронд арилжсан зүйлсийн нэг хэсэг болохгүй аливаа дүнг өөрөөр хэлбэл, тухайн худалдан авсан үйл ажиллагааны хувьд арилжааны нэг хэсэг болохгүй дүнг тодорхойлно. Худалдан авалтын аргыг хэрэглэх үйл явцын нэг хэсэг болгон нэгтгэгч нь зөвхөн худалдан авсан үйл ажиллагаанд шилжүүлсэн төлбөр ба уг худалдан авсан үйл ажиллагаатай хийсэн арилжаагаар олж эзэмшсэн хөрөнгө, хариуцсан өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Тусдаа ажил гүйлгээнүүдийг холбогдох УСНББОУС-уудын дагуу тайлагнана.**
110. Худалдан авалтаас өмнө нэгтгэгчийн хийсэн буюу түүний өмнөөс хийсэн, эсвэл юуны өмнө уг худалдан авсан үйл ажиллагааны (буюу түүний хуучин эздийн) ашиг тусын төлөө биш, харин нэгтгэгчийн болон нэгдсэн байгууллагын ашиг тусын төлөө хийсэн ажил гүйлгээ нь тусдаа ажил гүйлгээ байх магадлалтай байдаг. Худалдан авалтын аргыг хэрэглэхэд хамаарахгүй, тусдаа ажил гүйлгээний жишээг доор харуулав:
- (а) Нэгтгэгч ба худалдан авсан үйл ажиллагааны хооронд урьдчилан оршин байсан харилцааг барагдуулах үр дүн бүхий ажил гүйлгээ;
  - (б) Уг худалдан авсан үйл ажиллагааны ажилтнууд буюу хуучин эздэд ирээдүйн үйлчилгээний төлөө урамшуулал олгох ажил гүйлгээ; ба
  - (в) Нэгтгэгчийн худалдан авалттай холбоотой зардлыг төлөхийн тулд уг худалдан авсан үйл ажиллагаа буюу түүний хуучин эздэд нөхөн төлбөр олгох ажил гүйлгээ.



Холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ99–МЗУ106-р параграфт тусгасан.

*Худалдан авалттай холбоотой зардал*

111. Худалдан авалттай холбоотой зардал гэдэг нь уг худалдан авалтыг хийхийн тулд нэгтгэгчийн гаргасан зардал юм. Үүнд дараах зардал хамаарна: зуучлагчийн шимтгэл; зөвлөх, хуулийн, нягтлан бодох бүртгэлийн, үнэлгээний болон бусад мэргэжилтний буюу зөвлөх үйлчилгээний хөлс; ерөнхий удирдлагын зардал, үүн дотроо дотоод худалдан авалтын хэлтсийн үйл ажиллагааны зардал; өрийн болон өмчийн үнэт цаасыг бүртгүүлэх ба гаргах зардал. Нэгтгэгч нь худалдан авалттай холбоотой өртөг зардлыг ганцхан тохиолдлоос бусад үед зардал гарсан ба үйлчилгээг хүлээн авсан тайлант үед зардал гэж тайлагнана. Харин өрийн буюу өмчийн үнэт цаас гаргахтай холбоотой зардлыг УСНББОУС 28 ба УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрнө.

**Дараагийн тайлант үеийн хэмжилт ба нягтлан бодох бүртгэл**

112. **Ерөнхийдөө, нэгтгэгч нь худалдан авалтаар олж эзэмшсэн хөрөнгө, хариуцсан буюу хүлээсэн өр төлбөр, гаргасан өмчийн хэрэглүүрийг тэдгээрийн шинж төрлөөс хамааран тухайн зүйлсэд мөрдөх бусад УСНББОУС-уудын дагуу дараагийн тайлант үед хэмжиж, тайлагнана. Гэхдээ энэ Стандарт нь худалдан авалтаар олж эзэмшсэн дараах хөрөнгө, хариуцсан буюу хүлээсэн өр төлбөр, гаргасан өмчийн хэрэглүүрийг дараагийн тайлант үед хэмжих ба тайлагнах талаархи заавар удирдамжаар хангана:**

- (а) **Дахин олж эзэмшсэн эрх;**
- (б) **Худалдан авалтын өдрөөр хүлээн зөвшөөрсөн болзошгүй өр төлбөр;**
- (в) **Нөхөн төлбөрийн хөрөнгө;**
- (г) **Болзошгүй төлбөр; ба**
- (д) **Орлогын албан татвар (худалдан авалтын нөхцөлд тусгагдаагүй тохиолдолд)**

**Холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ107-МЗУ108-р параграфт тусгасан.**

*Дахин олж эзэмшсэн эрх*

113. Эрхийг тодорхой хугацаагаар олгосон тохиолдолд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн, уг дахин олж эзэмшсэн эрхийг түүнийг олгосон заавал биелүүлэх хэлцлийн үлдсэн хугацааны туршид хорогдуулна. Эрхийг тодорхой бус хугацаагаар олгосон бол уг үр дүнгийн байгууллага нь эрхийн үнэ цэнийн бууралтыг наад зах нь жил тутам болон үнэ цэнэ буурсан байж болох шинж тэмдэг илэрсэн аливаа тохиолдолд сорьж шалгана. Дахин олж эзэмшсэн эрхийг дараагийн тайлант үед гуравдагч талд борлуулдаг уг үр

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

дүнгийн байгууллага нь борлуулалтын олз буюу гарзыг тодорхойлохдоо тухайн биет бус хөрөнгийн дансны үнийг харгалзан тусгана.

*Худалдан авалтын үр дүнд өөрчлөгдөж болох шалгуурт үндэслэн нэгтгэгч буюу тухайн худалдан авсан үйл ажиллагааны хүлээн авсан шилжүүлэг, хөнгөлөлттэй зээл ба адилтгах өгөөж*

114. Худалдан авалтын үр дүнд өөрчлөгдөх шалгуурт үндэслэн нэгтгэгч буюу тухайн худалдан авсан үйл ажиллагааны өмнө хүлээн авсан шилжүүлэг, хөнгөлөлттэй зээл ба адилтгах өгөөжийг бусад УСНББОУС-уудын дагуу гүйцээх горимоор дахин үнэлнэ (холбогдох мөрдөх заавар удирдамжийг МЗУ109-МЗУ111-р параграфт тусгасан).

### *Болзошгүй өр төлбөр*

115. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа уг өр төлбөрийг барагдуулах, хүчингүй болгох буюу түүний хугацаа дуусах хүртэл нэгтгэгч нь худалдан авалтаар хүлээн зөвшөөрсөн болзошгүй өр төлбөрийг дараах дүнгүүдийн аль ихээр хэмжинэ:

- (а) УСНББОУС 19-ийн дагуу хүлээн зөвшөөрөх байсан дүн; ба
- (б) Анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хэрэв тохиромжтой бол УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ын дагуу хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүн.

Энэхүү шаардлагыг УСНББОУС 29-ийн дагуу тайлагнадаг гэрээний хувьд мөрдөхгүй.

### *Нөхөн төлбөрийн хөрөнгө*

116. Нэгтгэгч нь тухайн худалдан авалтын өдөр хүлээн зөвшөөрсөн нөхөн төлбөрийн хөрөнгийг дараагийн тайлант үе бүрийн эцэст, дүнгийн хувьд гэрээний аливаа хязгаарлалтанд хамаардаг нөхөн төлсөн өр төлбөр буюу хөрөнгөтэй ижил сууриар хэмжинэ, харин дараагийн тайлант үед бодит үнэ цэнээр нь хэмжээгүй нөхөн төлбөрийн хөрөнгийн хувьд түүний цуглуулагдах байдлын талаархи удирдлагын үнэлгээгээр хэмжинэ. Нэгтгэгч нь нөхөн төлбөрийн хөрөнгийг цуглуулан авсан, борлуулсан буюу түүнийг эзэмших эрхийг бусад байдлаар алдсан зөвхөн тийм тохиолдолд уг хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

### *Болзошгүй төлбөр*

117. Нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй төлбөрийн бодит үнэ цэнэд худалдан авалтын өдрөөс хойш гарсан зарим өөрчлөлт нь тухайн худалдан авалтын өдрөөр оршин байсан баримт материал ба нөхцөл байдлын талаархи боловч нэгтгэгч уг өдрөөс хойш олж авсан нэмэлт мэдээллийн үр дүн байж болох юм. Ийм өөрчлөлтүүд нь 103-107-р параграфт заасанчлан, хэмжилтийн хугацааны залруулга болно. Харин ашгийн зорилтот хэмжээг биелүүлэх, хувьцааны үнэ тохиролцсон түвшинд хүрэх, судалгаа ба хөгжлийн төслийн гол зорилго биелэх гэх мэт тухайн худалдан авалтын

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

өдрөөс хойшхи үйл явдлын үр дүн болох өөрчлөлт нь хэмжилтийн хугацааны залруулга биш юм. Хэмжилтийн хугацааны залруулгад хамаарахгүй, болзошгүй төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нэгтгэгч нь дараах байдлаар тайлагнана:

- (a) Цэвэр хөрөнгө/өмч гэж ангилсан болзошгүй төлбөрийг дахин хэмжихгүй бөгөөд түүний дараагийн тайлант үеийн барагдуулалтыг тухайн цэвэр хөрөнгө/өмчийн ангиллын хүрээнд тайлагнана.
- (б) Бусад болзошгүй төлбөрүүд нь:
  - (i) УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах бол тайлант үе бүрийн эцэст бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
  - (ii) УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй бол тайлант үе бүрийн эцэст бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

*Орлогын албан татвар (худалдан авалтын нөхцөлд тусгаагүй тохиолдолд)*

118. Улсын секторын байгууллагуудыг хамарсан худалдан авалт нь татварын эрх бүхий байгууллага уг худалдан авалтын дараа татвараас чөлөөлөхөд хүргэж болох юм. Чөлөөлөгдсөн татварыг тухайн нэгтгэгч нь орлогын албан татварыг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу гүйцээх горимоор тайлагнана.

### Тодруулга

119. **Нэгтгэгч нь дараах хугацааны аль нэгэнд гарч тохиолдсон худалдан авалтын шинж төрөл ба санхүүгийн үр нөлөөг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна:**
- (a) **Тухайн тайлант үеийн туршид; эсвэл**
  - (б) **Тухайн тайлант үеийн эцсээс хойш боловч санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө.**
120. 119-р параграфт дурдсан зорилгыг хангахын тулд нэгтгэгч нь тухайн тайлант үеийн туршид хийгдсэн худалдан авалт тус бүрийн хувьд дараах мэдээллийг тодруулна:
- (a) Худалдан авсан үйл ажиллагааны нэр ба тайлбар тодорхойлолт.
  - (б) Худалдан авалтын өдөр.
  - (в) Олж эзэмшсэн саналын эрхтэй өмчийн хувь оролцоо буюу адилтгах оролцооны хувийн жин.
  - (г) Худалдан авалт хийх үндсэн шалтгаан ба нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг хэрхэн олж авсан талаархи

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

тайлбар тодорхойлолт, үүн дотроо хэрэв боломжтой бол тухайн худалдан авалтын хууль зүйн үндэслэл.

- (д) Тухайн хүлээн зөвшөөрсөн гүүдвилийг бүрдүүлэх хүчин зүйлсийн чанарын шинжтэй тайлбар тодорхойлолт. Үүнд: уг худалдан авсан үйл ажиллагаа болон нэгтгэгчийн үйл ажиллагаануудыг нэгтгэснээр бий болохоор хүлээгдэж буй өргөжилтийн хэмнэлт, тусдаа хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангадаггүй биет бус хөрөнгө болон бусад хүчин зүйлс.
  - (е) Шилжүүлсэн нийт төлбөрийн тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ ба төлбөрийн дараах гэх мэт гол анги тус бүрийн тэрхүү худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ:
    - (i) Мөнгө;
    - (ii) Бусад биет болон биет бус хөрөнгө, үүн дотроо, тухайн нэгтгэгчийн үйл ажиллагаа буюу хяналтанд буй байгууллага;
    - (iii) Хүлээсэн өр төлбөр, жишээлбэл; болзошгүй төлбөрийн өр төлбөр;
    - (iv) Нэгтгэгчийн өмчийн хувь оролцоо, үүнд: гаргасан эсвэл гаргах боломжтой хэрэглүүрийн буюу хувь оролцооны тоо, тэдгээр хэрэглүүр буюу хувь оролцооны бодит үнэ цэнийг хэмжих арга.
  - (ж) Болзошгүй төлбөрийн хэлцэл болон нөхөн төлбөрийн хөрөнгийн хувьд:
    - (i) Тухайн худалдан авалтын өдрөөр хүлээн зөвшөөрсөн дүн;
    - (ii) Хэлцлийн тайлбар тодорхойлолт ба төлбөрийн дүнг тодорхойлох суурь;
    - (iii) Гарц үр дүнгийн хамаарах мужийн тооцоолол (дискаунтчлаагүй), хэрэв хамаарах мужийг тооцоолж чадахгүй бол энэ тухай, түүнчлэн хамаарах мужийг яагаад тооцоолж чадахгүй байгаа учир шалтгаан. Хэрэв төлбөрийн хамгийн их дүнг хязгаарлаагүй бол нэгтгэгч нь энэ тухай тодруулга хийнэ.
  - (и) Олж эзэмшсэн авлагын хувьд:
    - (i) Авлагын бодит үнэ цэнэ;
    - (ii) Заавал биелүүлэх хэлцлийн дагуу авах нийт дүн;
    - (iii) Заавал биелүүлэх хэлцлийн мөнгөн гүйлгээг үл цуглуулагдах талаархи тухайн худалдан авалтын өдрөөрх хамгийн сайн тооцоолол.
- Зээл, шууд санхүүгийн түрээс ба авлагын бусад аливаа анги гэх мэт авлагын гол ангиудаар тодруулгыг хийнэ.
- (к) Олж эзэмшсэн хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн гол анги тус бүрийн хувьд тухайн худалдан авалтын өдрөөр хүлээн зөвшөөрсөн дүнгүүд.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (л) 77-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн болзошгүй өр төлбөр тус бүрийн хувьд УСНББОУС 19-ийн 98-р параграфээр шаардсан мэдээлэл. Болзошгүй өр төлбөрийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүйн улмаас түүнийг хүлээн зөвшөөрөөгүй бол нэгтгэгч нь дараах зүйлсийг тодруулна:
  - (i) УСНББОУС 19-ийн 100-р параграфээр шаардсан мэдээлэл;
  - (ii) Өр төлбөрийг найдвартай хэмжиж чадахгүй байгаа шалтгаан.
- (м) Татварын зорилгоор хасагдах дүн болохоор хүлээгдэж буй гүүдвилийн нийт дүн.
- (н) 109-р параграфын дагуу худалдан авалтаар олж эзэмшсэн хөрөнгө ба хариуцсан өр төлбөрөөс тусад нь хүлээн зөвшөөрдөг ажил гүйлгээний хувьд:
  - (i) Ажил гүйлгээ тус бүрийн тайлбар тодорхойлолт;
  - (ii) Нэгтгэгч нь ажил гүйлгээ тус бүрийг хэрхэн тайлагнадаг тухай;
  - (iii) Ажил гүйлгээ бүрийн хувьд хүлээн зөвшөөрсөн дүн ба уг дүн бүрийг хүлээн зөвшөөрсөн санхүүгийн тайлангийн мөрийн зүйл;
  - (iv) Хэрэв ажил гүйлгээ нь урьдчилан оршин байсан харилцааны үр дүнтэй барагдуулалт бол уг барагдуулалтын дүнг тодорхойлоход ашигласан арга.
- (о) Дээрх (н) заалтад шаардсан, уг тусдаа хүлээн зөвшөөрдөг ажил гүйлгээний тодруулга нь доорх зүйлсийг агуулсан байна: худалдан авалттай холбоотой өртгийн дүн, мөн тухайн өртгөөс зардал гэж хүлээн зөвшөөрсөн дүн ба тэдгээр зардлыг хүлээн зөвшөөрсөн санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйл буюу зүйлс. Түүнчлэн, зардал гэж хүлээн зөвшөөрөөгүй, тухайн гаргалтын аливаа өртгийн дүн ба тэдгээрийг хэрхэн хүлээн зөвшөөрсөн талаар тодруулга хийнэ.
- (п) Үүссэн гарзыг нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн худалдан авалтын хувьд (86-р параграфыг үзнэ үү):
  - (i) 86-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн аливаа гарзын дүн ба уг гарзыг хүлээн зөвшөөрсөн санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйл;
  - (ii) Уг ажил гүйлгээ нь гарз үүсгэсэн шалтгааны талаархи тайлбар тодорхойлолт.
- (р) Тохиролцоот худалдан авалтын хувьд (88–90-р параграфыг үзнэ үү):
  - (i) 88-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн аливаа олзын дүн ба уг олзыг хүлээн зөвшөөрсөн санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйл;
  - (ii) Уг ажил гүйлгээ нь олз үүсгэсэн шалтгааны талаархи тайлбар тодорхойлолт.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (с) Нэгтгэгч нь тухайн худалдан авалтын өдрөөр худалдан авсан үйл ажиллагааны тоогоор илэрхийлж болох өмчийн хувь оролцоо буюу адилтгах оролцооны 100 хувиас бага хэсгийг эзэмшдэг худалдан авалт тус бүрийн хувьд:
- (i) Худалдан авалтын өдрөөр хүлээн зөвшөөрсөн уг худалдан авсан үйл ажиллагаан дахь хяналтын бус хувь оролцооны дүн ба тэрхүү дүнгийн хэмжилтийн суурь;
  - (ii) Бодит үнэ цэнээр хэмжсэн, уг худалдан авсан үйл ажиллагаан дахь хяналтын бус хувь оролцоо тус бүрийн хувьд, тэрхүү үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэлгээний арга техник ба гол орцууд.
- (т) Үе шаттайгаар хүрсэн худалдан авалтын хувьд:
- (i) Худалдан авалтын өдрийн яг өмнө нэгтгэгчийн эзэмшиж байсан уг худалдан авсан үйл ажиллагаан дахь өмчийн хувь оролцооны тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ;
  - (ii) Худалдан авалтаас өмнө (100-р параграфыг үзнэ үү) нэгтгэгчийн эзэмшиж байсан уг худалдан авсан үйл ажиллагаан дахь өмчийн хувь оролцоог бодит үнэ цэнээр дахин хэмжсэний үр дүнд хүлээн зөвшөөрсөн аливаа олз, гарзын дүн ба тэрхүү олз, гарзыг хүлээн зөвшөөрсөн санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйл.
- (у) Дараах мэдээлэл:
- (i) Тухайн тайлант үеийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан, уг худалдан авсан үйл ажиллагааны худалдан авалтын өдрөөс хойшхи орлого, зардал болон ашиг, алдагдлын дүн;
  - (ii) Тайлант жилийн туршид хийгдсэн бүх худалдан авалтын хувьд тэдгээрийн худалдан авалтын өдөр нь уг жилийн эхэнд байсан мэтээр харуулсан, тэрхүү нэгдсэн байгууллагын тухайн тайлант жилийн орлого, зардал болон ашиг, алдагдал.

Энэ параграфтаар шаардсан аль нэг мэдээллийн тодруулгыг хийх практик боломжгүй бол нэгтгэгч нь энэ тухай тодруулга хийх бөгөөд яагаад практик боломжгүй байсныг тайлбарлана. Энэхүү Стандартад “практик боломжгүй” гэсэн нэр томъёог УСНББОУС 3-д заасантай ижил утгаар хэрэглэсэн болно.

121. Тухайн тайлант үеийн туршид хийгдсэн, тус тусдаа материаллаг бус боловч нэгдсэн дүнгээрээ материаллаг байх худалдан авалтын хувьд нэгтгэгч нь 120-р параграфын (д)-(у) заалтанд шаардсан мэдээллийг нийт дүнгээр тодруулна.
122. Хэрэв худалдан авалтын өдөр нь тухайн тайлант үеийн эцсээс хойш боловч санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн өдрөөс өмнө бол уг худалдан авалтын анхны тайлагнал нь санхүүгийн тайланг гаргахыг

зөвшөөрсөн өдрөөс өмнө иж бүрэн бус байхаас бусад тохиолдолд нэгтгэгч нь 120-р параграфтаар шаардсан мэдээллийг тодруулна. Ийм тохиолдолд нэгтгэгч нь ямар тодруулгыг хийж чадаагүй ба яагаад хийж чадахгүй байгаа шалтгааныг тодруулна.

123. **Нэгтгэгч нь тайлант үед эсвэл өмнөх тайлант үеүдэд гарч тохиолдсон худалдан авалттай холбоотойгоор тухайн тайлант үед хүлээн зөвшөөрсөн залруулгын санхүүгийн үр нөлөөг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлан хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна.**
124. 123-р параграфт заасан зорилгыг хангахын тулд нэгтгэгч нь материаллаг худалдан авалт тус бүрийн хувьд, эсвэл тус тусдаа материаллаг бус боловч нэгдсэн дүнгээрээ материаллаг байх худалдан авалтын хувьд дараах мэдээллийг тодруулна:
- (a) Худалдан авалтын анхны тайлагнал нь тодорхой хөрөнгө, өр төлбөр, хяналтын бус хувь оролцоо буюу төлбөрийн зүйлсийн хувьд иж бүрэн бус (103-р параграфыг үзнэ үү), иймээс тухайн худалдан авалтаар санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг зөвхөн нөхцөлт байдлаар тодорхойлдог бол:
    - (i) Тухайн худалдан авалтын тайлагнал иж бүрэн бус байгаагийн шалтгаан;
    - (ii) Анхны тайлагнал нь иж бүрэн бус тэдгээр хөрөнгө, өр төлбөр, өмчийн хувь оролцоо (эсвэл түүнтэй адилтгах зүйл) буюу төлбөрийн зүйлс; ба
    - (iii) Тухайн тайлант үеийн туршид 107-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн уг хэмжилтийн хугацааны аливаа залруулгын шинж төрөл ба дүн.
  - (б) Худалдан авалтын өдрөөс хойш уг байгууллага нь болзошгүй төлбөрийн хөрөнгийг цуглуулах, борлуулах буюу бусад байдлаар түүний эрхийг алдах хүртэлх, эсвэл байгууллага нь болзошгүй төлбөрийн өр төлбөрийг барагдуулах буюу тухайн өр төлбөрийг хүчингүй болгох, өр төлбөрийн хугацаа дуусах хүртэлх тайлант үе бүрийн хувьд:
    - (i) Тухайн хүлээн зөвшөөрсөн дүнгийн аливаа өөрчлөлт, үүн дотроо барагдуулалтаас үүссэн аливаа зөрүү;
    - (ii) Гарц үр дүнгийн хамаарах мужийн аливаа өөрчлөлт (дискаунтчлаагүй) ба тэдгээр өөрчлөлтийн шалтгаан;
    - (iii) Болзошгүй төлбөрийг хэмжихэд ашигласан үнэлгээний арга техник ба гол загварын орцууд.
  - (в) Худалдан авалтаар хүлээн зөвшөөрсөн болзошгүй өр төлбөрийн хувьд, нэгтгэгч нь нөөцийн анги тус бүрийн хувьд УСНББОУС 19-ийн 97 ба 98-р параграфтаар шаардсан мэдээллийг тодруулна.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (г) Тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх гүүдвилийн дансны үнийн залруулгын тайлан, үүнд дараах зүйлсийг тусад нь харуулах;
- (i) Тухайн тайлант үеийн эхэн дэх нийт дүн ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзын дүн.
  - (ii) Тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн нэмэлт гүүдвил.
  - (iii) Тухайн тайлант үед хамаарах дүнгүүдийг орлогын албан татварыг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу дараагийн тайлант үед хүлээн зөвшөөрсний үр дүн болох залруулга.
  - (iv) Тухайн тайлант үеийн туршид үл хүлээн зөвшөөрсөн гүүдвил.
  - (v) УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Нэгжийн Үнэ Цэнийн Бууралт*-ын дагуу тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз. (УСНББОУС 26 нь энэхүү шаардлагаас гадна гүүдвилийн нөхөгдөх дүн болон үнэ цэнийн бууралтын талаархи мэдээллийг тодруулахыг шаарддаг.)
  - (vi) УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-ний дагуу тухайн тайлант үеийн туршид үүссэн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн цэвэр зөрүү.
  - (vii) Тухайн тайлант үеийн туршид дансны үнэд гарсан аливаа бусад өөрчлөлт.
  - (viii) Тайлант үеийн эцэс дэх нийт дүн ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарз.
- (д) Тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн, дараах шинж бүхий аливаа олз буюу гарзын дүн ба тайлбар:
- (i) тухайн тайлант үед болон өмнөх тайлант үед хийгдсэн худалдан авалтаар олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөртэй холбоотой; ба
  - (ii) тэдгээрийн тодруулга нь уг нэгдсэн байгууллагын санхүүгийн тайланг ойлгоход хамааралтай байхуйц тийм хэмжээ, шинж төрөл буюу нөлөөтэй байх.
- (е) Төлөх ёстой татварыг худалдан авалтын нөхцлийн үр дүн болгон чөлөөлсөн бол (78-79-р параграфыг үзнэ үү):
- (i) Чөлөөлсөн татварын дүн;
  - (ii) Нэгтгэгч нь өөрөө татварын алба бол татварын авлагад хийсэн залруулгын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл.
125. Хэрэв энэ болон бусад УСНББОУС-уудаар шаардсан тусгай тодруулга нь 119 ба 123-р параграфт заасан зорилгыг хангахгүй бол нэгтгэгч нь тэдгээр зорилгыг хангахад шаардлагатай аливаа нэмэлт мэдээллийг тодруулна.



## Хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилт

### Хүчин төгөлдөр болох хугацаа

126. 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх анхны тайлант жилийн эхэнд эсвэл түүнээс хойшхи худалдан авалтын өдөр буюу нийлүүлэх өдөр бүхий улсын секторын нэгдлийн хувьд энэхүү Стандартыг гүйцээх горимоор мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

### Шилжилт

127. Худалдан авалтын өдөр эсвэл нийлүүлэх өдөр нь энэ Стандартын мөрдөлтөөс өмнө байх улсын секторын нэгдлээс үүссэн хөрөнгө, өр төлбөрийн хувьд энэ Стандартыг мөрдсөнөөр залруулга хийхгүй.
128. Худалдан авалтын өдөр нь энэ Стандартыг байгууллага анх мөрдсөн өдрөөс өмнө байх худалдан авалтаас үүссэн болзошгүй төлбөрийн үлдэгдлийн хувьд энэ Стандартыг анх мөрдсөнөөр залруулга хийхгүй. Тэдгээр үлдэгдлийн дараагийн тайлант үеийн тайлагналын хувьд 129-132-р параграфыг мөрдөнө. Худалдан авалтын өдөр нь энэ Стандартыг байгууллага анх мөрдсөн өдөр буюу түүнээс хойш байх худалдан авалтаас үүссэн болзошгүй төлбөрийн үлдэгдлийн тайлагналын хувьд 129-132-р параграфыг мөрдөхгүй. 129-132-р параграфт дурдсан, худалдан авалт гэдэг нь энэ Стандартыг мөрдөхөөс өмнө байх тийм худалдан авалтын өдөр бүхий худалдан авалтад зөвхөн хамаарна.
129. Худалдан авалтын гэрээ нь ирээдүйн үйл явдлын болзошгүй байдлын хувьд худалдан авалтын өртөгт залруулга хийхээр заасан тохиолдолд хэрэв тухайн залруулга нилээд магадлалтай бөгөөд түүнийг найдвартай хэмжиж чадах бол нэгтгэгч нь худалдан авалтын өдрөөр тэрхүү худалдан авалтын өртөгт уг залруулгын дүнг тусган оруулна.
130. Худалдан авалтын гэрээ нь ирээдүйн нэг буюу хэд хэдэн үйл явдлаас болзошгүй хамааран тухайн худалдан авалтын өртөгт залруулга хийхийг зөвшөөрдөг байж болох юм. Тухайлбал; залруулга нь ашгийн тохиролцсон түвшинг ирээдүйн тайлант үеүдэд хадгалах буюу тодорхой түвшинд хүргэх, эсвэл гаргасан хэрэглүүрийн тухайн зах зээлийн үнийг хадгалах эсэхээс хамаардаг байж болно. Хэдийгээр зарим тодорхой бус байдал оршин байдаг боловч мэдээллийн найдвартай байдлыг алдагдуулахгүйгээр тухайн худалдан авалтыг анх тайлагнахдаа ийм аливаа залруулгын дүнг ихэвчлэн тооцоолох боломжтой байдаг. Хэрэв тэдгээр ирээдүйн үйл явдлууд гарч тохиолдоогүй буюу уг тооцооллыг хянан засварлах шаардлагатай бол тухайн худалдан авалтын өртгийг зохих ёсоор залруулна.

131. Худалдан авалтын гэрээнд ийм залруулга хийхээр заасан боловч хэрэв тухайн залруулга нь нилээд магадлалтай биш, эсвэл түүнийг найдвартай хэмжиж чадахгүй бол худалдан авалтыг анх тайлагнахдаа тэрхүү худалдан авалтын өртөгт уг залруулгын дүнг тусган оруулахгүй. Хэрэв тухайн залруулга нь дараагийн тайлант үед нилээд магадлалтай болсон ба түүнийг найдвартай хэмжиж чадах бол нэмэлт төлбөрийг уг худалдан авалтын өртгийн залруулга гэж үзнэ.
132. Зарим тохиолдолд, нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааны хяналтын эрхийг авсаны хариуд өөрийн өгсөн хөрөнгө, гаргасан өмчийн хэрэглүүр, хариуцсан буюу хүлээсэн өр төлбөр зэргийн үнэ цэнийн бууралтын хувьд нөхөн төлбөр болгон тухайн борлуулагчид дараагийн тайлант үед төлбөр төлөх шаардлагатай байж болох юм. Тухайлбал; нэгтгэгч нь худалдан авалтын өртгийн нэг хэсэг болгон өөрийн гаргасан өмчийн буюу өрийн хэрэглүүрийн зах зээлийн үнэд баталгаа өгсөн бөгөөд анхны тодорхойлсон өртгийг хэвээр хадгалахын тулд нэмэлт өмчийн буюу өрийн хэрэглүүр гаргах шаардлагатай бол ийм тохиолдол үүсдэг. Энэ тохиолдолд худалдан авалтын өртгийн нэмэгдэлтийг хүлээн зөвшөөрөхгүй. Өмчийн хэрэглүүрийн хувьд, нэмэлт төлбөрийн бодит үнэ цэнийг уг хэрэглүүрийг анх гаргахад хамаарах үнэ цэнийн тэнцүү хэмжээний бууралтаар харилцан суутгадаг. Өрийн хэрэглүүрийн хувьд, нэмэлт төлбөрийг анхны гаргалтын урамшууллын бууралт эсвэл хөнгөлөлтийн нэмэгдэлт гэж үздэг.
133. Энэ Стандартыг хараахан мөрдөж эхлээгүй бөгөөд худалдан авалтын аргыг ашиглан тайлагнасан (гүүдвилийн хорогдуулгыг агуулсан) нэг буюу хэд хэдэн улсын секторын нэгдэл бүхий хамтын байгууллага гэх мэт байгууллага нь МЗУ114-МЗУ115-р параграфт заасан шилжилтийн нөхцлүүдийг даган мөрдөнө.

*Орлогын албан татвар*

134. Худалдан авалтын өдөр эсвэл нийлүүлэх өдөр нь энэ Стандартыг мөрдөхөөс өмнө байх улсын секторын нэгдлийн хувьд, нэгтгэгч буюу үр дүнгийн байгууллага нь орлогын албан татварыг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын эсвэл үндэсний холбогдох стандартын шаардлагуудыг гүйцээх горимоор мөрдөнө. Харин энэ Стандартыг мөрдсөн өдрөөс эхлэн, нэгтгэгч буюу үр дүнгийн байгууллага нь орлогын албан татварыг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын эсвэл үндэсний холбогдох стандартаар шаардсан аливаа өөрчлөлтийг ашиг, алдагдлын залруулга байдлаар (хэрэв орлогын албан татварыг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын эсвэл үндэсний холбогдох стандартаар шаардсан бол ашиг, алдагдлаас гадуур) хүлээн зөвшөөрнө.

## Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 40-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

### Тодорхойлолт (5-р параграфыг үзнэ үү)

МЗУ1. Энэхүү Стандартын 5-р параграфт үр дүнгийн байгууллагыг “нийлүүлэлтээр нэгдэж буй хоёр буюу хэд хэдэн үйл ажиллагаануудын үр дүн болох байгууллага” гэж тодорхойлсон. Үр дүнгийн байгууллага нь улсын секторын нэгдлийн оролцогч нэг тал эхлээд биш байдаг. Үр дүнгийн байгууллага нь шинэ байгууллагын хуулийн хэлбэртэй байж болно эсвэл нэгдэгч үйл ажиллагаануудын аль нэгийг хуулийн шинжийг хадгалж болох юм. Гэхдээ үр дүнгийн байгууллага нь шинэ байгууллагын эдийн засгийн мөн чанарыг ихэвчлэн агуулдаг. Нэгдлийн оролцогч нэг тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг бөгөөд нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай нэгдлийн хувьд тухайн үр дүнгийн байгууллага нь шинэ байгууллагын мөн чанартай байх нь уг нэгдлийн шинж төлөв юм.

### Улсын секторын нэгдлийг тодорхойлох (6-р параграфыг үзнэ үү)

МЗУ2. Энэхүү Стандартын 5-р параграфт улсын секторын нэгдлийг “тусдаа үйл ажиллагаануудыг улсын секторын нэг байгууллагад нэгтгэн оруулалт” гэж тодорхойлсон. Улсын секторын нэг байгууллага гэсэн хэллэг нь дан ганц байгууллагад эсвэл эдийн засгийн нэгдмэл байгууллагад хамаарч болно. Улсын секторын зарим дахин зохион байгуулалт нь улсын секторын нэгээс олон нэгдлийг агуулсан байж болно. Улсын секторын нэгдэл хийгдсэн байж болох нөхцөл байдлуудад дараах зүйлс хамаарна:

- (а) Хамтын гэрээгээр;
- (б) Албадлагаар (жишээлбэл; хуулийн шаардлагаар).

МЗУ3. Энэхүү Стандартын 5-р параграфт үйл ажиллагааг “бараа, үйлчилгээ нийлүүлэх замаар тухайн байгууллагын зорилтуудад хүрэхийн тулд эрхлэн явуулж, удирдан зохицуулах боломжтой нэгдмэл цогц үйл ажиллагаа ба холбогдох хөрөнгө, өр төлбөр” гэж тодорхойлсон.

МЗУ4. Үйл ажиллагаа нь орц, түүнчлэн гарц үүсгэх боломж бүхий тэдгээр орцуудад хэрэглэх процессоос бүрддэг. Үйл ажиллагаа нь ихэвчлэн гарцтай байх боловч үйл ажиллагаа болох тийм шалгуурыг хангахын тулд гарц нь заавал нэгдмэл цогц үйл ажиллагаа ба холбогдох хөрөнгө, өр төлбөртэй байхыг шаардахгүй. Энэ Стандартын зорилгын хувьд үйл ажиллагааны гурван элементийг дараах байдлаар тодорхойлдог:

- (а) **Орц:** Нэг буюу хэд хэдэн процессыг түүнд хэрэглэснээр гарцыг үүсгэдэг буюу ингэж үүсгэх чадвар боломж бүхий эдийн засгийн аливаа нөөц.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (б) **Процесс:** Орц буюу орцуудад хэрэглэснээр гарцыг үүсгэдэг буюу үүсгэх чадвар боломж бүхий аливаа систем, стандарт, аргачлал, дүрэм, журам.
- (в) **Гарц:** Орцууд болон тэдгээрт хэрэглэсэн процессуудын үр дүн бөгөөд бараа, үйлчилгээг нийлүүлдэг буюу нийлүүлэх чадвар боломжтой байдаг.

Орц, гарцын тодорхойлолтууд нь СБПУ 3, *Үйлчилгээний Гүйцэтгэлийн Мэдээллийн Тайлагнал*-д заасан, тодорхойлолтуудаас өөр байна. Яагаад гэвэл, СБПУ 3 нь тухайн байгууллагын гаднын хэрэглэгчдэд чиглэдэг, харин үйл ажиллагаа нь байгууллагын дотоод хэрэглэгчидтэй байж болох юм.

- МЗУ5. Тодорхойлсон зорилгын төлөө эрхлэн явуулж, удирдан зохицуулах боломжтой байхын тулд үйл ажиллагаа болон хөрөнгө, өр төлбөрийн нэгдмэл цогц нь орцууд ба тэдгээрт хэрэглэх процесс гэсэн хоёр чухал элементийг шаарддаг. Гарцыг үүсгэхийн тулд энэхүү хоёр элементийг хамтад нь ашигладаг буюу ашиглах юм. Гэвч үйл ажиллагаа буюу үйл ажиллагаануудыг хүлээн авдаг байгууллага нь тухайлбал, уг үйл ажиллагааг өөрийн орцууд болон процессуудтай нэгтгэснээр гарцыг үргэлжлүүлэн бий болгох чадвар боломжтой бол тухайн үйл ажиллагаа нь түүний шилжүүлэгч тэрхүү үйл ажиллагааг эрхлэн явуулахад ашигладагтай адил бүх орц буюу процессуудтай байх албагүй юм.
- МЗУ6. Үйл ажиллагааны элементүүдийн шинж төрөл нь үйл ажиллагаа явуулж буй сектор, тухайн байгууллагын үйл ажиллагааны (ажиллагаануудын) бүтэц зохион байгуулалт, үүн дотроо уг байгууллагын хөгжлийн үе шатаас хамааран өөр өөр байдаг. Тогтсон үйл ажиллагаа нь янз бүрийн олон орц, процесс, гарцтай байдаг бол шинэ үйл ажиллагаа нь ихэвчлэн цөөн орц, процесстэй, заримдаа ердөө ганц гарцтай (бүтээгдэхүүнтэй) байдаг. Бараг бүх үйл ажиллагаа нь мөн өр төлбөртэй байдаг боловч шинэ үйл ажиллагаа нь заавал өр төлбөртэй байх албагүй юм.
- МЗУ7. Хөгжлийн үе шатандаа буй үйл ажиллагаа ба хөрөнгө, өр төлбөрийн нэгдмэл цогц нь гарцгүй байж болох юм. Хэрэв гарцгүй бол тэрхүү цогц нь үйл ажиллагаа мөн эсэхийг түүнийг хүлээн авсан байгууллага тодорхойлохын тулд бусад хүчин зүйлсийг харгалзан үзвэл зохино. Уг цогц дараах шинжтэй эсэх нь тийм хүчин зүйлсэд хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
- (а) төлөвлөсөн үндсэн үйл ажиллагаагаа эхэлсэн эсэх;
  - (б) ажиллах хүч, оюуны өмч, бусад орц ба тэдгээр орцуудад хэрэглэх процессуудтай эсэх;
  - (в) гарцыг үйлдвэрлэх төлөвлөгөөг хэрэгжүүлж буй эсэх; ба
  - (г) гарцыг хүлээн авах хэрэглэгчдийг олж авах боломжтой эсэх.

Хөгжлийн үе шатандаа буй тухайн нэгдмэл цогц үйл ажиллагаа ба хөрөнгө, өр төлбөр нь үйл ажиллагааны шалгуурыг хангахын тулд түүнд дээр дурдсан бүх хүчин зүйлс заавал байх албагүй юм.

- МЗУ8. Тухайн нэгдмэл цогц үйл ажиллагаа ба хөрөнгө, өр төлбөр нь үйл ажиллагаа болох эсэхийг тодорхойлохдоо, бусад байгууллага нь уг нэгдмэл цогцыг үйл ажиллагаа байдлаар эрхлэн явуулж, удирдан зохицуулах чадвар боломжтой эсэхэд үндэслэдэг. Иймээс тухайн цогц нь үйл ажиллагаа эсэхийг үнэлэхэд, шилжүүлэгч тал нь уг цогцыг үйл ажиллагаа байдлаар ажиллуулж байсан эсвэл нэгтгэгч нь уг цогцыг үйл ажиллагаа байдлаар ажиллуулах санаа зорилготой эсэх нь хамааралгүй юм.
- МЗУ9. Эсрэг нотолгоо байхгүй тохиолдолд, гүүдвил бүхий тухайн цогц үйл ажиллагаа ба хөрөнгө, өр төлбөрийг нэг үйл ажиллагаа гэж үздэг. Гэвч үйл ажиллагаа нь заавал гүүдвилтэй байх албагүй юм.

### **Улсын секторын нэгдлийн ангилал (7-14-р параграфыг үзнэ үү)**

#### *Хяналтын үнэлгээ (7-8-р параграфыг үзнэ үү)*

- МЗУ10. Улсын секторын нэгдлийн оролцогч аль нэг тал нь тухайн нэгдлийн үр дүнд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг бол тэрхүү нэгдлийн эдийн засгийн мөн чанараас хамааран уг нэгдлийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилна. Нэгдлийн оролцогч аль нэг тал нь хяналтыг олж авдаггүй бол уг нэгдлийг нийлүүлэлт гэж ангилна. Энэхүү үнэлгээг хийх эхний алхам нь уг улсын секторын нэгдлээс өмнө оршин байсан байгууллагуудын аль нэг нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэхийг тодорхойлох явдал юм. Улсын секторын нэгдлээс өмнө оршин байсан байгууллагуудыг лавлагаа болгосноор үүнийг тодорхойлдог тул энэ нь УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-гийн дагуу хийх хяналтын үнэлгээнээс өөр байдаг. УСНББОУС 35-ын дагуу улсын секторын нэгдлээс хойш оршин буй байгууллагуудыг лавлагаа болгосноор хяналтын үнэлгээг хийдэг.
- МЗУ11. Улсын секторын нэгдлийн оролцогч нэг тал нь нэгдлийн үр дүнд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь УСНББОУС 35-д заасан, зарчмууд болон заавар удирдамжийг дагаж мөрдөнө. Уг зарчмууд болон заавар удирдамжийг даган мөрдөхдөө, “байгууллага хянадаг” гэсэн хэллэгийг “байгууллага нь ... хяналтыг олж авсан” гэж, “бусад байгууллага” гэдгийг “үйл ажиллагаа” гэж орлуулан уншина. Жишээлбэл; улсын секторын нэгдлийн оролцогч нэг тал нь энэ Стандартын зорилгын хувьд тухайн нэгдлийн үр дүнд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэхийг тодорхойлохдоо, УСНББОУС 35-ын 20-р параграфыг дараах байдлаар уншина (нэмэлт өөрчлөлт оруулсан текстийг ташуу үсгээр харуулсан):

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

Иймээс байгууллага нь дараах бүх зүйлсийг *олж авсан* бол, зөвхөн тийм тохиолдолд уг байгууллага нь *үйл ажиллагааны хяналтыг олж авдаг*:

- (а) Тухайн үйл ажиллагааны хувьд бүрэн эрх (23-29-р параграфыг үзнэ үү);
- (б) Тухайн үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээх үүрэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрх (30-34-р параграфыг үзнэ үү); ба
- (в) Тухайн үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөөлөхийн тулд уг үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж (35-37-р параграфыг үзнэ үү).

- МЗУ12. УСНББОУС 35-д заасан, зарчмууд болон заавар удирдамжийг дагаж мөрдөхдөө, байгууллага нь МЗУ13-МЗУ18-р параграфыг харгалзан үзнэ.
- МЗУ13. Төлбөр шилжүүлснээр (өөрөөр хэлбэл, мөнгө болон бусад хөрөнгийг шилжүүлснээр эсвэл өр төлбөрийг үүсгэснээр) үндсэндээ хийгдсэн улсын секторын нэгдэл нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг тухайн нэг байгууллага олж авахад ихэвчлэн хүргэдэг.
- МЗУ14. Өмчийн хувь оролцоог солилцсноор үндсэндээ хийгдсэн улсын секторын нэгдэл нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг тухайн нэг байгууллага олж авахад ихэвчлэн хүргэдэг. Өмчийн хувь оролцооны солилцоог хамрах нэгдэл нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авахын тулд тухайн нэг байгууллага хангалттай саналын эрхтэй болоход ихэвчлэн хүргэдэг. Тухайн байгууллага нь маш олон тооны цөөнхийн саналын хувь оролцоотой бөгөөд мэдэгдэхүйц саналын эрх бүхий бусад эзэд буюу эздийн зохион байгуулалттай бүлэг байхгүй тохиолдолд олонхийн саналын эрх бүхий байгууллага байхгүй үед ч ийм тохиолдол үүсэж болно.
- МЗУ15. Өмчийн хувь оролцооны гаргалтыг хамарсан улсын секторын нэгдэл нь сөрөг худалдан авалт үүсэхэд хүргэж болох юм (МЗУ66-МЗУ71-р параграфыг үзнэ үү). Улсын секторын нэгдлийн оролцогч нэг тал нь үйл ажиллагаануудын хяналтыг олж авсан эсэхийг тодорхойлохдоо байгууллага нь энэхүү боломжит байдлыг харгалзан үзнэ.
- МЗУ16. Хоёроос олон байгууллагуудыг хамарсан улсын секторын нэгдлийн хувьд тухайн нэгдлийг санаачилсан уг улсын секторын нэгдлийн оролцогч тал (хэрэв байгаа бол) нь тэрхүү нэгдлийн бусад оролцогч талуудтай харьцуулахад үйл ажиллагааны хяналтыг олж авах илүү их магадлалтай байдаг.
- МЗУ17. Нэгдлийг хийхийн тулд шинэ байгууллагыг үүсгэн байгуулдаг улсын секторын нэгдлийн хувьд тухайн байгууллага нь нэгдэл хийгдэхээс өмнө

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

оршин байсан зөвхөн тийм тохиолдолд тэрхүү байгууллага нь үйл ажиллагааны хяналтыг олж авч болох юм. Уг шинэ байгууллага нь нэгдэл хийгдэхээс өмнө оршин байгаагүй тохиолдолд тэрхүү нэгдлээс өмнө оршин байсан нэгдлийн оролцогч талуудын аль нэг нь үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэхийг тухайн байгууллага харгалзан үзнэ.

МЗУ18. Энэхүү заавар удирдамжийн мөрдөлтөөр тухайн нэгдлийн аль нэг талыг нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан гэж тодорхойлдог бол уг нэгдлийн эдийн засгийн мөн чанараас хамааран тэрхүү нэгдлийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилна. Нэгдлийн эдийн засгийн мөн чанар нь нийлүүлэлтийн мөн чанартай эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь 9-14-р параграф болон МЗУ19-МЗУ50-р параграфт дурдсан, заавар удирдамжийг харгалзан үзнэ. Заавар удирдамжийн даган мөрдөлт нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг тухайн нэгдлийн аль нэг оролцогч тал олж авсан гэж тодорхойлдоггүй бол уг нэгдлийг нийлүүлэлт гэж ангилна.

*Улсын секторын нэгдлийн ангиллын үнэлгээ (9-14-р параграфыг үзнэ үү)*

МЗУ19. Улсын секторын нэгдлийн аль нэг оролцогч тал нь нэгдлийн үр дүнд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан бол тухайн нэгдлийг түүний эдийн засгийн мөн чанараас хамааран нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилна. Нэгдлийн эдийн засгийн мөн чанар нь нийлүүлэлтийн мөн чанартай эсэхийг үнэлэхдээ байгууллага нь уг улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанар болон 12-14-р параграфт дурдсан үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ. Нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанаргүй нэгдлийг худалдан авалт гэж ангилна. Ийм үнэлгээг хийхдээ байгууллага нь дараах заавар удирдамжийг харгалзан үзнэ.

*Эдийн засгийн мөн чанар (9-р параграфыг үзнэ үү)*

МЗУ20. 12-13-р параграфт дурдсан, үзүүлэлтүүдийн дангаар нь, эсвэл нэгдсэн дүнгээр нь хийсэн шинжилгээ нь дүгнэлтийн шинжтэй үр дүнг бий болгодог бөгөөд уг нэгдлийн эдийн засгийн мөн чанар нь нийлүүлэлтийн мөн чанартай эсэхийг тодорхойлох хангалттай нотолгоог ихэвчлэн бүрдүүлдэг. Нийлүүлэлт гэж ангилагдахын тулд нэгдэл нь эдгээр үзүүлэлтүүдийн аль алиныг хангах албагүй юм.

МЗУ21. 12-13-р параграфт дурдсан, үзүүлэлтүүдийг харгалзан үзсэнээр дүгнэлтийн бус шинжтэй үр дүнг гаргасан буюу уг нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг ойлгомжтой тодорхойлох тийм хангалттай нотолгоог бүрдүүлээгүй бол байгууллага нь 14-р параграфт дурдсан нэмэлт асуудлуудыг харгалзан үзнэ.

МЗУ22. Нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанар бол тухайн үр дүнгийн байгууллагын хуулийн хэлбэрээс үл хамааран ихэвчлэн шинэ байгууллагыг үүсгэн байгуулах явдал юм. Нэгдлийн аль нэг оролцогч тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг нэгдэлд энэ нь мөн адил хамаарна. Хэрэв улсын секторын нэгдэл нь түүний оролцогч

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

аль нэг оршин байсан хэвээр байх тийм эдийн засгийн мөн чанартай бол энэ нь тухайн нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо болж болох юм. Ерөнхий хяналтанд буй үйл ажиллагаануудын нэгдлийн хувьд, эцсийн хяналт тавигч байгууллага нь нэгдлийн өмнө ба дараа тухайн үйл ажиллагааг хянасаар байх нь энэхүү хүчин зүйлийн ач холбогдлыг бууруулдаг.

МЗУ23. Нийлүүлэлт нь улсын секторын нэгдлийн нэг хэсэг болох үйл ажиллагаануудын нэгтгэлийг агуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, нийлүүлэлт нь тухайн нэгдлийн оролцогч талуудын хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа үүсэхэд хүргэдэггүй. Хэрэв нэгдлийн дараа тэдгээр үйл ажиллагаануудын аль нэг нь тухайн нэгдлийн аль нэг оролцогч талын хяналтанд буй байгууллага байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг бол энэ нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо болж болох юм.

МЗУ24. Худалдан авалт нь үндсэндээ хоёр буюу хэд хэдэн талуудын хоорондох хамтын хэлцэл бөгөөд ихэвчлэн худалдаа арилжааны мөн чанартай байдаг. Гэвч улсын секторын хувьд, нэгдлийн оролцогч нэг тал нь улсын секторын нэгдлийг тухайн нэгдлийн оролцогч нөгөө талд тулган хэрэгжүүлэх боломжтой байж болно. Энэ нь хамтын хэлцлээр олж авч болох өгөөжтэй адилтгах эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тухайн байгууллага олж авахад хүргэдэг тохиолдолд уг улсын секторын нэгдэл нь худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай байх нилээд магадлалтай юм. Жишээлбэл; төв засгийн газар нь цар хүрээний нэгдэл гаргахын тулд үйл ажиллагаануудыг түүнд шилжүүлэхийг орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас шаардсанаар өөрөө санхүүжилт олгож байсан үйлчилгээг төвлөрүүлж болох юм. Байгууллага нь сайн дурын ажил гүйлгээгээр олж авч болох өгөөжтэй адилтгах эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг олж авдаггүй тохиолдолд тухайн улсын секторын нэгдэл нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай байх нилээд магадлалтай юм.

МЗУ25. Улсын секторын нэгдлийн үзүүлэлтүүд болон мөн чанарыг харгалзан үзсэний дараа тухайн улсын секторын нэгдэл нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо хангалтгүй бол уг нэгдлийг худалдан авалт гэж ангилна.

Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд (12-р параграфыг үзнэ үү)

МЗУ26. Нийлүүлэлт нь тухайн үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох төлбөрийг ихэвчлэн агуулаагүй байдаг. Харин эсрэгээр, худалдан авалт нь тухайн үйл ажиллагааны хяналтыг олж авсан тал ба үйл ажиллагааны хяналтаа алдсан талын хоорондох төлбөрийн солилцоог ихэвчлэн агуулсан байдаг.

МЗУ27. Тухайн шилжүүлсэн үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй талд тэрхүү эрхээ өгсөний хариуд нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго



## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

бүхий төлбөр төлөлт нь уг улсын секторын нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор хангадаг. Ийм тохиолдолд уг нэгдлийг худалдан авалт гэж ангилна.

- МЗУ28. Үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилгогүй боловч тухайлбал, улсын секторын нэгдлийг хийхэд гаргасан өртөг зардлыг нөхөн олгох санаа зорилготой төлбөр төлөлт нь уг бизнесийн нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор хангаж болох юм.
- МЗУ29. Худалдан авалт нь төлбөрийн солилцоогүйгээр хийгдэж болно. Жишээлбэл; хувь хүн нь үйл ажиллагаагаа Засгийн газрын байгууллагад гэрээслэн өгч болно. Иймээс төлбөр үл төлөлт нь улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарын талаархи нотолгоог дангаараа бүрдүүлэхгүй. Төлбөрийг үнэлэхдээ байгууллага нь тухайн төлбөрийг яагаад төлсөн эсвэл яагаад төлөөгүй гэсэн учир шалтгааныг мөн харгалзан үзнэ.
- МЗУ30. Улсын секторын нэгдэл нь төлбөр төлөлтийг агуулаагүй тохиолдолд байгууллага нь яагаад төлбөр төлөөгүй талаархи учир шалтгааныг харгалзан үзнэ. Хуучин эзэн нь тухайн үйл ажиллагааны цэвэр хөрөнгө дэх өөрийн эрхийг өгсөн эсвэл албадлагын байдлаар (жишээлбэл; нөхөн төлбөргүйгээр битүүмжлэн хураалт) түүний эрх дууссан бол тухайн нэгдэл нь худалдан авалт гэсэн нотолгоо байж болох юм.
- МЗУ31. Тухайн үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй ямар нэг тал байхгүйн улмаас улсын секторын нэгдэл нь төлбөр төлөлтийг агуулаагүй тохиолдолд уг нэгдэл нь ихэвчлэн нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай байдаг. Худалдан авалт нь үйл ажиллагааг хуучин эзнээс түүний шинэ эзэнд өгөх шилжүүлэлтийг агуулдаг. Тухайн үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй ямар нэг тал байхгүй бол хуучин эзэн гэж байхгүй бөгөөд уг нэгдэл нь ихэвчлэн худалдан авалт биш байдаг. Цогц байгууллагыг зөвхөн шилжүүлж байгаа тохиолдолд ийм хувилбар үүсдэг; бие даасан үйл ажиллагааг шилжүүлэх тохиолдолд уг үйл ажиллагааг шилжүүлэн өгч буй байгууллага нь хуучин эзэн бөгөөд тухайн үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй байдаг. Хуучин эзэн (эзэд) байхгүй байгууллагын жишээнд нутгийн засаг захиргаа, зарим ашгийн төлөө бус байгууллага хамаарна.

Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүд (13-р параграфыг үзнэ үү)

- МЗУ32. Худалдан авалт нь тухайн нэгдэлд бүх талууд сайн дурын үндсэн дээр оролцохыг ихэвчлэн шаарддаг. Иймээс тухайн нэгдлийн аль нэг талын оролцогч талыг шийдвэр гаргах үйл явцад оролцуулахгүйгээр гуравдагч этгээд улсын секторын нэгдлийг хийсэн тохиолдолд энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор хангаж болох юм.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- МЗУ33. Өөр бусад тохиолдолд хэдийгээр улсын секторын нэгдлийг гуравдагч этгээд хийдэг боловч улсын секторын нэгдлийн оролцогч талууд нь тухайн нэгдлийн нөхцөлд янз бүрийн зэрэг хэмжээтэйгээр нөлөө үзүүлэх боломжтой байдаг. Нэгдэлд оролцогч талуудын үзүүлэх нөлөөллийн, ялангуяа нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан талын нөлөөллийн зэрэг хэмжээ нэмэгдэхийн хэрээр уг нэгдлийн эдийн засгийн мөн чанарын талаар дүгнэлт гаргаж болох магадлал улам бүр багасна.
- МЗУ34. Жишээлбэл, зохицуулагч байгууллага нь нэгдэх талаархи удирдамж чиглэлийг тухайн нэгдлийн оролцогч талуудад өгсөн боловч нэгдлийн нөхцлийг талууд тодорхойлохыг зөвшөөрсөн байж болно. Энэхүү улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг талууд нэгдэх ёстой гэсэн зохицуулагчийн шийдвэрээр бус, харин тухайн нэгдлийн оролцогч талуудын тохиролцсон нэгдлийн нөхцлөөр тодорхойлох магадлалтай байдаг.
- МЗУ35. Нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан тухайн нэгдлийн оролцогч тал нь нөгөө талд тэрхүү нэгдлийг тулган хүлээлгэх чадвар боломжтой тохиолдолд энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоог бүрдүүлэхгүй. Жишээлбэл; засгийн газар нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг түүний хувьцаа эзэмшигчдийн саналыг үл харгалзан төрийн өмчид авахаар шийдвэрлэж болох юм. Засгийн газар (нэгдлийн оролцогч тал) тухайлбал, хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид авахаар тулган хүлээлгэх чадвар боломжтой байдал нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоог бүрдүүлэхгүй. Нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан тухайн нэгдлийн оролцогч тал нь нөгөө талд тэрхүү нэгдлийг тулган хүлээлгэх чадвар боломжтой тохиолдолд энэ нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо болно.
- МЗУ36. Улсын секторын нэгдэл нь түүний оролцогч тал тус бүрийн иргэдийн санал асуулгаар зөвшөөрөгддөг тохиолдолд энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоог бүрдүүлж болох юм. Ийм шаардлага нь нэгдлийн оролцогч талууд тухайн нэгдлийг сайн дураараа хийх эрх чөлөөгүй бөгөөд нэгдлийг хийх эсэх эцсийн шийдвэрийг гуравдагч талууд гаргадаг гэсэн нотолгоо болно. Гэвч иргэд нь худалдан авалтын нөхцөлтэй адил байх тийм нөхцөл бүхий нэгдлийг санал асуулгаар зөвшөөрөх боломжтой байна.
- МЗУ37. Улсын секторын нэгдэл нь ерөнхий хяналтанд буй хоёр талын хооронд хийгдсэн тохиолдолд энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоог бүрдүүлж болох юм. Ерөнхий хяналтанд буй улсын секторын нэгдлийг хяналт тавигч байгууллага санаачилж, түүний нэрийн өмнөөс хийдэг бөгөөд тухайн хяналт тавигч байгууллага нь уг нэгдлийн нөхцлийг ихэвчлэн тодорхойлдог. Жишээлбэл; засгийн газар нь засаг захиргааны буюу улс төрийн шалтгаанаар хоёр яамыг нэгтгэхээр шийдвэрлэх ба тухайн нэгдлийн нөхцлийг тусгайлан зааж болох юм. Ийм тохиолдолд нэгдлийг хийх эсэх болон нэгдлийн нөхцлийг уг хяналт тавигч

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

байгууллага тодорхойлж байна. Энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо болно.

МЗУ38. Зарим тохиолдолд ерөнхий хяналтанд буй хоёр үйл ажиллагаа нь сайн дураараа нэгдэхийг зөвшөөрч болох юм. Гэвч ийм шийдвэр нь зөвшөөрлийг шууд өгдөг, үгүй эсэхээс үл хамааран тухайн хяналт тавигч байгууллагын зөвшөөрлийг ихэвчлэн шаарддаг. Хяналт тавигч байгууллагын зөвшөөрлийг шаарддаг тохиолдолд энэ нь тухайн нэгдлийг хийх эсэх эцсийн шийдвэр болон нэгдлийн нөхцлийг уг хяналт тавигч байгууллага тодорхойлдог гэсэн нотолгоог илэрхийлнэ. Иймээс энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо болно.

МЗУ39. Хяналт тавигч байгууллага нь тухайн нэгдлийг санаачлах, нэгдлийн нөхцлийг тодорхойлох, эсвэл нэгдлийг (шууд буюу шууд бусаар) зөвшөөрөн батлах байдлаар улсын секторын нэгдэлд оролцсон гэсэн нотолгоо байхгүй зөвхөн тийм тохиолдолд уг нэгдэл нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэж үзэх нотолгоогүй байдаг. Ийм тохиолдолд байгууллага нь улсын секторын нэгдлийн ангиллыг тодорхойлохдоо бусад бүх хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүд нь уг нэгдлийг нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлох хангалттай нотолгоог бүрдүүлдэггүй тохиолдолд харгалзан үзэх нэмэлт асуудлууд (14-р параграфыг үзнэ үү)

МЗУ40. Төлбөртэй болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийн шинжилгээ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлох хангалттай нотолгоог бүрдүүлдэггүй буюу дүгнэлтийн бус шинжтэй үр дүнг бий болгодог тохиолдолд аль ангилал болон түүнд хамаарах нягтлан бодох бүртгэлийн арга нь дараах мэдээллээр хангах эсэхийг тухайн байгууллага харгалзан үзнэ:

(а) Санхүүгийн тайлагналын зорилтуудыг хамгийн сайнаар биелүүлэх; ба

(б) Чанарын шинжүүд (ЧШ)-ийг хамгийн сайнаар хангах.

МЗУ41. Төлбөртэй болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийн шинжилгээ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлох хангалттай нотолгоог бүрдүүлдэг бөгөөд дүгнэлтийн шинжтэй үр дүнг ихэвчлэн бий болгодог. Яагаад гэвэл, төлбөртэй болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүд нь гажих нөхцлөөс бусад бүх тохиолдолд улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарын талаархи нотолгоог бүрдүүлдэг. Иймээс тэдгээр үзүүлэлтүүд хангагдсан гэдэг нь тодорхой тохиолдолд ангиллыг тодорхойлохдоо 14-р параграфт дурдсан, нэмэлт асуудлуудыг харгалзан үзэхгүй.

МЗУ42. Төлбөртэй болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийн шинжилгээ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай

эсэхийг тодорхойлох хангалттай нотолгоог бүрдүүлдэггүй буюу дүгнэлтийн бус шинжтэй үр дүнг бий болгодог тохиолдолд аль ангилал нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хамгийн сайнаар биелүүлэх мэдээллээр хангах эсэхийг тухайн байгууллага харгалзан үзнэ. Улсын секторын нэгдлийг худалдан авалт эсвэл нийлүүлэлт гэж ангилах эсэх тодорхойлолт нь тухайн нэгдлийн санхүүгийн тайлагналд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Иймээс арга тус бүрээр ханган бүрдүүлэх мэдээлэл болон тэрхүү мэдээллийн үндсэн хэрэглэгчдийг харгалзан үзэх нь чухал ач холбогдолтой юм.

МЗУ43. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга нь нэгдэгч үйл ажиллагаа, тэдгээрийн эзэд буюу уг үр дүнгийн байгууллагад өөрсдийн хувь оролцоогоо нэгтгэж буй оролцогч тус бүрийн байр сууринаас нэгдлийг авч үздэг. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг ашигласнаар нэгдэгч үйл ажиллагаанууд нь тухайн тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийг уг нийлүүлэх өдрөөрх өөрсдийн санхүүгийн тайлан дахь тэдгээрийн дансны үнээр хэмжинэ. Ийм мэдээлэл нь уг нийлүүлэх өдрөөрх тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын хөрөнгө, өр төлбөрийн нэгтгэсэн түүхэн мэдээнд үндэслэн тухайн үр дүнгийн байгууллагын гүйцэтгэлийг үнэлэх, үйл ажиллагааны үр дүнг өмнөх тайлант үеүдтэй зэрэгцүүлэхэд хэрэглэгчдэд тусалж болох юм. Гэвч нягтлан бодох бүртгэлийн тууштай бодлоготой байхын тулд залруулга хийх шаардлагатай тохиолдолд энэхүү зэрэгцүүлэгдэх боломжтой байдал буурч болох юм. Уг нийлүүлэх өдрөөс өмнө бодит үнэ цэнээр бүртгэсэн хөрөнгө ба өр төлбөрөөс бусад, хөрөнгө болон өр төлбөртэй холбоотой ирээдүйн мөнгөн гүйлгээний үнэ цэнийн зах зээлийн хүлээлтийн талаархи мэдээлэл үүнд хамаарахгүй.

МЗУ44. Худалдан авалтын арга нь нэгтгэгчийн зүгээс буюу бусад үйл ажиллагаануудын хяналтыг олж авсан байгууллагын байр сууринаас нэгдлийг авч үздэг. Нэгтгэгч нь цэвэр хөрөнгийг худалдан авдаг буюу бусад байдлаар түүний хяналтыг олж авдаг бөгөөд тухайн олж эзэмшсэн хөрөнгө, хариуцсан өр төлбөр, үүн дотроо уг худалдан авсан үйл ажиллагааны өмнө хүлээн зөвшөөрдөггүй байсан хөрөнгө, өр төлбөрийг өөрийн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрдөг. Ийм мэдээлэл нь хийсэн анхны хөрөнгө оруулалт, тэдгээр хөрөнгө оруулалтын дараагийн тайлант үеийн гүйцэтгэлийг үнэлэх, түүнчлэн уг нэгтгэгчийн оруулсан хөрөнгө оруулалтанд үндэслэн бусад байгууллагуудын үр дүнтэй түүнийг харьцуулахад тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тусалдаг. Мөн тэдгээр хөрөнгө, өр төлбөртэй холбоотой ирээдүйн мөнгөн гүйлгээний үнэ цэнийн зах зээлийн хүлээлтийн талаархи мэдээлэл үүнд хамаарна. Энэ аргын дагуу, тухайн худалдан авсан үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийг дахин үнэлдэг боловч худалдан авалтаас өмнө уг нэгтгэгчийн эзэмшиж байсан хөрөнгө, өр төлбөрийн үнэлгээнд нөлөө үзүүлэхгүй. Түүнчлэн, 85(а) ба 85(б) параграфт дурдсан дүнгүүдийн хоорондох харилцаа болон бусад хүчин зүйлсээс (жишээлбэл; тохиролцоот худалдан авалт) хамааран энэ арга нь олз, гарзыг ашиг, алдагдлаар дамжуулан нэн даруй хүлээн зөвшөөрөхөд хүргэж болох юм.

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

МЗУ45. Хандлага тус бүрээр бүрдүүлэх мэдээллийг доорх хүснэгтэнд товчоолон харуулав.

	<b>Нийлүүлэлт</b>	<b>Худалдан авалт</b>
Байр суурь	Нэгдэгч үйл ажиллагаанууд болон тэдгээрийн эзэд буюу оролцогч тус бүрийн байр сууринаас авч үзэх.	Нэгтгэгчийн байр сууринаас авч үзэх.
Хэрэглэгчийн мэдээлэл	Уг нийлүүлэх өдрөөрх тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын хөрөнгө, өр төлбөрийн нэгтгэсэн түүхэн мэдээнд үндэслэн тухайн үр дүнгийн байгууллагын гүйцэтгэлийг үнэлэх, үйл ажиллагааны үр дүнг өмнөх тайлант үеүдтэй зэрэгцүүлэхэд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах.	Хийсэн анхны хөрөнгө оруулалт ба тэдгээр хөрөнгө оруулалтын дараагийн тайлант үеийн гүйцэтгэлийг үнэлэхэд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах.
Тайлагнасан үнэ цэнийн сууриуд	Тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийг тэрхүү нийлүүлэх өдрөөрх уг нэгдэгч үйл ажиллагаануудын санхүүгийн тайлан дахь тэдгээрийн дансны үнээр хэмжих.	Тухайн худалдан авсан үйл ажиллагааны тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийг дахин үнэлдэг боловч уг нэгтгэгчийн эзэмшиж байсан хөрөнгө, өр төлбөрийн үнэлгээнд нөлөө үзүүлэхгүй. Тэдгээр хөрөнгө, өр төлбөртэй холбоотой ирээдүйн мөнгөн гүйлгээний үнэ цэнийн зах зээлийн хүлээлтийн талаархи мэдээлэл үүнд хамаарна.
Үйл ажиллагааны үр дүнг өмнөх тайлант үеүдтэй зэрэгцүүлэх чадвар боломж	Үйл ажиллагааны үр дүнг өмнөх тайлант үеүдтэй зэрэгцүүлэхэд тусалж болох юм. Нягтлан бодох бүртгэлийн тууштай бодлоготой байхын тулд залруулга хийх шаардлагатай тохиолдолд энэхүү зэрэгцүүлэгдэх боломжтой байдал буурч болох юм.	Үйл ажиллагааны үр дүнг өмнөх тайлант үеүдтэй зэрэгцүүлэхэд хүндрэлтэй байдаг.

МЗУ46. Төлбөртэй болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийн шинжилгээ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлох хангалттай нотолгоог бүрдүүлдэггүй буюу

дүгнэлтийн бус шинжтэй үр дүнг бий болгодог тохиолдолд аль ангилал тухайн санхүүгийн тайлагналын зорилтуудыг хамгийн сайнаар биелүүлэх мэдээллээр хангах эсэхийг харгалзан үзэх нь уг улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарын талаархи нотолгоог бүрдүүлнэ.

- МЗУ47. Төлбөртэй болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийн шинжилгээ нь уг нэгдлийн ангиллыг тодорхойлох хангалттай нотолгоог бүрдүүлдэггүй буюу дүгнэлтийн бус шинжтэй үр дүнг бий болгодог тохиолдолд аль ангилал нь хамааралтай байх, үнэн зөв толилуулга, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх ба шалгах боломжтой байх гэсэн ЧШ-ийг хамгийн сайнаар биелүүлэх мэдээллээр хангах эсэхийг тухайн байгууллага харгалзан үзнэ. Энэхүү үнэлгээг хийхдээ байгууллага нь нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгагдсан мэдээллийн материаллаг байдал, өртөг ба өгөөж, чанарын шинжүүдийн тэнцвэртэй байдал зэрэг хязгаарлалтуудыг мөн харгалзан үздэг.
- МЗУ48. Улсын секторын нэгдлийн ангиллыг харгалзан үзэх үед зарим чанарын шинжүүд нь бусдаасаа илүү ач холбогдолтой байдаг. Жишээлбэл; нэгдэл нь нийлүүлэлт эсвэл худалдан авалт эсэхийг харгалзан үзэх үед цаг хугацаандаа байх гэсэн шинж нь ойлгомжтой байх шинжээс ач холбогдол багатай байх юм.
- МЗУ49. Байгууллага нь чанарын шинжүүд болон мэдээллийн хязгаарлалтуудыг тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн байр сууринаас авч үздэг. Үүнд дараах асуултуудыг харгалзан үзэх боловч энэ жагсаалтанд бүгдийг хамруулаагүй болно.
- (а) Аль ангилал нь тухайн улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг хамгийн үнэн зөв илэрхийлэх вэ, аль ангилал нь өөрийн хуулийн хэлбэрээс өөр байх вэ? Уг ангилал нь тухайн байгууллагын санхүүгийн үр дүн ба санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлж байна уу?
  - (б) Аль ангилал нь улсын секторын нэгдлийн шинж төрлийг ойлгоход хэрэглэгчдэд туслах вэ? Жишээлбэл; нийлүүлэлтийн үед хүлээн зөвшөөрсөн нийт хөрөнгө ба хүлээн зөвшөөрсөн нийт өр төлбөрийн хоорондох аливаа зөрүүг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг бол худалдан авалтын хувьд нэгтгэгч нь гүүдвил болон олз, гарзыг тухайн тайлант үед хүлээн зөвшөөрнө. Аль арга хандлага нь уг нэгдлийн шинж төрлийг ойлгоход хэрэглэгчид хамгийн сайнаар туслах вэ?
  - (в) Ажил гүйлгээний хувьд бүрдүүлсэн мэдээлэл нь зэрэгцүүлэгдэх боломжтой тохиолдолд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад хамгийн сайнаар үйлчилдэг. Улсын секторын ижил төсөөтэй нэгдлүүдийг хэрхэн ангилдаг вэ?
- МЗУ50. Төлбөртэй болон шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийн шинжилгээ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлох хангалттай нотолгоог бүрдүүлдэггүй буюу

дүгнэлтийн бус шинжтэй үр дүнг бий болгодог тохиолдолд аль ангилал чанарын шинжүүдийг хамгийн сайнаар биелүүлэх мэдээллээр хангах эсэхийг харгалзан үзэх нь уг улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарын талаархи нотолгоог бүрдүүлдэг.

## **Нийлүүлэлтийн тайлагнал**

*Нэгдэгч үйл ажиллагаануудын хооронд гарсан ажил гүйлгээг устгаж цэвэрлэх (22-р параграфыг үзнэ үү)*

МЗУ51. Үр дүнгийн байгууллага нь нэгдэгч үйл ажиллагаануудын хооронд гарсан бүх ажил гүйлгээний үр нөлөөг устгаж цэвэрлэнэ. Олон ажил гүйлгээний хувьд устгалтыг автоматаар хийдэг. Жишээлбэл; нэгдэгч нэг үйл ажиллагаа нь нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд тухайн нийлүүлэх өдрөөс өмнө төлбөртэйгээр үйлчилгээ үзүүлдэг байсан. Үйлчилгээ үзүүлсэн уг нэгдэгч үйл ажиллагааны орлогыг тухайн нийлүүлэх өдөр тэрхүү нэгдэгч үйл ажиллагааны хуримтлагдсан ашиг, алдагдалд тусгадаг. Үйлчилгээг хүлээн авсан уг нэгдэгч үйл ажиллагааны зардлыг тухайн нийлүүлэх өдөр тэрхүү нэгдэгч үйл ажиллагааны хуримтлагдсан ашиг, алдагдалд тусгадаг. Үр дүнгийн байгууллага нь эдгээр дүнгүүдийн аль алиныг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.

МЗУ52. Нэгдэж буй хоёр үйл ажиллагааны хооронд гарсан ажил гүйлгээний үр дүнд нэгдэгч нэг үйл ажиллагаа нь хөрөнгө хүлээн зөвшөөрдөг, нэгдэгч нөгөө үйл ажиллагаа нь харгалзах өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг тохиолдолд устгалтыг автоматаар хийдэггүй байж болох юм. Тухайн үр дүнгийн байгууллага нь тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн аль алиныг устган цэвэрлэж, уг хөрөнгө, өр төлбөрийн хоорондох аливаа зөрүүг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг.

*Ашиглах дансны үнэ (26-27-р параграфыг үзнэ үү)*

МЗУ53. Нэгдэгч үйл ажиллагааг өмнө нь худалдан авалтаар олж эзэмшсэн (өөрөөр хэлбэл, энэ нь өмнө худалдан авсан үйл ажиллагаа байсан) бол уг нэгдэгч үйл ажиллагааны тусдаа санхүүгийн тайлан дахь түүний хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайлан дахь тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн дансны үнээс өөр байж болно. Худалдан авалтын хувьд, хяналт тавигч байгууллага нь нэгдэгч үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмждэг. Гэвч уг нэгдэгч үйл ажиллагаа (өөрөөр хэлбэл, өмнө худалдан авсан үйл ажиллагаа) нь тусдаа санхүүгийн тайлангаа бэлтгэсэн хэвээр байгаа бол хяналт тавигч байгууллага нь түүний өмнөх дансны үнийг ашиглана. Хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайлан дахь бодит үнэ цэнийн хэмжилтийг уг нэгдэгч үйл ажиллагаанд адилтган хэрэглэхгүй.

МЗУ54. 26-27-р параграфт заасан шаардлагуудыг хангахын тулд үр дүнгийн байгууллага нь нэгдэгч үйл ажиллагаануудын тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийг тухайн нэгдэгч үйл ажиллагаануудын санхүүгийн тайлан

дахь тэдгээрийн дансны үнээр уг нийлүүлэх өдөр хэмжих бөгөөд тэрхүү үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэх үүднээс дансны үнийг тохируулах шаардлагад захирагдана. Үр дүнгийн байгууллага нь тэдгээр хөрөнгө, өр төлбөрийг тухайн хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайланд тэдгээрийн дансны үнээр хэмжихгүй.

*Нэгдэгч нэг үйл ажиллагаа нь нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө нь олгосон лиценз ба адилтгах эрхүүд (32-р параграфыг үзнэ үү)*

МЗУ55. Эрх олгогчийн хүлээн зөвшөөрсөн эсвэл хүлээн зөвшөөрөөгүй нэг буюу хэд хэдэн хөрөнгүүдийг ашиглахын тулд тухайн нэгдэгч нэг үйл ажиллагаанаас нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө нь олгосон байсан лиценз ба адилтгах эрхийг уг үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтийн нэг хэсэг байдлаар хүлээн авч болох юм. Технологийн лицензийн хэлцлийн дагуу тухайн нэгтгэгчийн технологийг ашиглах эрх нь ийм эрхийн жишээнд хамаарна. Үр дүнгийн байгууллага нь ийм лиценз буюу адилтгах эрхийг тодорхойлогдох биет бус хөрөнгө байдлаар хүлээн зөвшөөрөх бөгөөд нийлүүлэх өдрөөрх уг нэгдэгч үйл ажиллагааны санхүүгийн тайлан дахь түүний дансны үнээр нь тэрхүү биет бус хөрөнгийг хэмжинэ. Уг лиценз буюу адилтгах эрх өмнө нь заавал биелүүлэх хэлцлийн нэг хэсэг байсан тул тэрээр УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-д заасан, салган тусгаарлаж болох ба заавал биелүүлэх хэлцлээс үүссэн байх гэсэн хоёр шалгуурын аль алиныг хангана. Нэгдэгч нэг үйл ажиллагаанаас нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө нь олгосон байсан лиценз буюу адилтгах эрхийн дараагийн тайлант үеийн тайлагналын талаархи заавар удирдамжийг 47-р параграфт тусгасан.

МЗУ56. Нэгдэгч нэг үйл ажиллагаанаас нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө нь олгосон лиценз буюу адилтгах эрх, түүнчлэн суурь хөрөнгийн (уг суурь хөрөнгө нь хүлээн зөвшөөрсөн хөрөнгө байсан тохиолдолд) аль алины үнэ цэнийн бууралтыг тухайн үр дүнгийн байгууллага нь тэрхүү нийлүүлэх өдөр УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* ба УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын дагуу үнэлнэ.

*Төлөх ёстой татварыг нийлүүлэлтийн үр дүнд чөлөөлөх (тухайн нийлүүлэлтийн нөхцөлд тусгасан тохиолдолд) (33-34-р параграфыг үзнэ үү)*

МЗУ57. Нэгдэгч үйл ажиллагааны төлөх ёстой татварыг тухайн нийлүүлэлтийн нөхцлийн нэг хэсэг байдлаар татварын эрх бүхий байгууллагаас чөлөөлсөн тохиолдолд үр дүнгийн байгууллага нь үүнтэй холбоотойгоор ямар нэг дүнг хүлээн зөвшөөрөхгүй. Нийлүүлэлтийн дараа татвараас чөлөөлсөн тохиолдолд тухайн үр дүнгийн байгууллага нь 49-р параграфын шаардлагуудыг даган мөрдөнө. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг хэрэглэх тохиолдолд үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтийн нөхцөлд тусгагдсан тэдгээр дүнг уг нийлүүлэлтээс өмнө үл хүлээн зөвшөөрсөнтэй адилаар тайлагнана. Нэгдэгч үйл ажиллагааны төлөх ёстой бөгөөд татварын эрх бүхий



байгууллагаас чөлөөлөөгүй татварыг уг үр дүнгийн байгууллага нь орлогын албан татварыг зохицуулдаг, нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу тайлагнана.

МЗУ58. Нийлүүлэлтийн үр дүнд уг үр дүнгийн байгууллага нь өөрөө татварын эрх бүхий байгууллага болсон тохиолдолд тус байгууллага нь уг нэгдэгч үйл ажиллагааны төлөх ёстой боловч чөлөөлөгдсөн татвартай холбоотой аливаа татварын авлагыг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ын дагуу үл хүлээн зөвшөөрнө.

*Гүүдвилийн хүлээн зөвшөөрөлт (36-р параграфыг үзнэ үү)*

МЗУ59. Нийлүүлэлт нь гүүдвил үүсэхэд хүргэдэггүй, иймээс үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтээс үүсэх гүүдвилийг хүлээн зөвшөөрөхгүй. Нийлүүлэлтийн үр дүнд үүссэн цэвэр хөрөнгө/өмчийн аргыг 37-38-р параграфт тусгайлан заасан.

МЗУ60. Нэгдэгч үйл ажиллагаа нь өмнөх худалдан авалтын үр дүнд гүүдвилийг урьд нь хүлээн зөвшөөрсөн байсан бол үр дүнгийн байгууллага нь уг гүүдвилийг өөрийн санхүүгийн байдлын эхлэлийн тайланд хүлээн зөвшөөрнө.

*Нийлүүлэлтийн үр дүнд өөрчлөгдөж болох шалгуурт үндэслэн тухайн нэгдэгч үйл ажиллагааны хүлээн авсан шилжүүлэг, хөнгөлөлттэй зээл ба адилтгах өгөөжийн дараагийн тайлант үеийн хэмжилт (48-р параграфыг үзнэ үү)*

МЗУ61. Нийлүүлэлтийг хийхээс өмнө, нэгдэгч үйл ажиллагаа нь тодорхой шалгуурт үндэслэн гуравдагч талаас шилжүүлэг хүлээн авч болно. Жишээлбэл; өрхийн дундаж орлого нь босго шалгуураас доогуур байх нутгийн захиргаадад үндэсний засгийн газраас буцалтгүй тусламж олгодог байж болох юм. Хоёр нутгийн захиргааны нийлүүлэлтийн хувьд нэг нутгийн захиргаа нь тухайн шалгуурыг хангаж, буцалтгүй тусламжийг авдаг, харин нөгөө нутгийн захиргаа нь шалгуурыг хангаагүй бөгөөд буцалтгүй тусламжийг авдаггүй. Нийлүүлэлтийн дараах уг нэгдсэн шинэ нутгийн захиргааны айл өрхийн дундаж орлого нь босго шалгуураас өндөр эсвэл бага байх бөгөөд энэ нь тухайн олгох буцалтгүй тусламжийн дүнг санхүүжүүлэгч дахин хянан үнэлэхэд хүргэж болох юм.

МЗУ62. Үр дүнгийн байгууллага нь буцалтгүй тусламжийн дүнд оруулсан аливаа засвар өөрчлөлтийг уг нийлүүлэлтийн нэг хэсэг байдлаар тайлагнадаггүй боловч санхүүжүүлэгч нь өөрийн санаа зорилгыг мэдэгдсэн тэр агшинд тус үр дүнгийн байгууллага нь аливаа засвар өөрчлөлтийг бусад УСНББОУС-уудын дагуу тайлагнана.

МЗУ63. Хөнгөлөлттэй зээл болон бусад өгөөжийн хувьд үүнтэй адилтгах нөхцөл байдал үүсэж болох юм. Үр дүнгийн байгууллага нь эдгээр ажил гүйлгээний аливаа засвар өөрчлөлтийг уг нийлүүлэлтийн нэг хэсэг байдлаар тайлагнадаггүй боловч санхүүжүүлэгч нь өөрийн санаа

зорилгыг мэдэгдсэн тэр агшинд тус үр дүнгийн байгууллага нь аливаа засвар өөрчлөлтийг бусад УСНББОУС-уудын дагуу тайлагнана.

*Тайлант үеийн туршид хийгдсэн нийлүүлэлт*

МЗУ64. 50-52-р параграфын шаардлагуудыг биелүүлэхийн тулд үр дүнгийн байгууллага нь 54(ж) параграфт заасан тодруулгыг хийснээр санхүүгийн тайланг толилуулах сонголт хийж болох боловч нийлүүлэх өдрөөс өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайланг толилуулах албагүй юм. Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэх өдрөөс өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайланг толилуулах сонголт хийгээгүй тохиолдолд уг нийлүүлэлтээс өмнөх уг нэгдэгч үйл ажиллагаануудын талаархи мэдээллийн хувьд өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг дараах байдлаар хангана:

- (а) Нийлүүлэх өдрөөс яг өмнө дуусгавар болсон тайлант үеийн (энэ нь хэсэгчилсэн тайлант үе байж болно) хувьд санхүүгийн тайланг тухайн нэгдэгч үйл ажиллагаануудын нэрийн өмнөөс гаргасан тохиолдолд тэрхүү санхүүгийн тайланг тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын нэрийн өмнөөс гаргасан гэдгийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд мэдэгдэх.
- (б) Нийлүүлэх өдрөөс яг өмнө дуусгавар болсон тайлант үеийн (энэ нь хэсэгчилсэн тайлант үе байж болно) хувьд санхүүгийн тайланг тухайн нэгдэгч үйл ажиллагаануудын нэрийн өмнөөс гаргаагүй тохиолдолд 54(и) параграфтаар шаардсан тодруулгыг хийх.

МЗУ65. Зохицуулагч байгууллагын шаардлагыг биелүүлэхийн тулд нэгдэгч үйл ажиллагаанууд болон үр дүнгийн байгууллага нь энэ Стандартаар шаардснаас гадна бусад мэдээллийг толилуулах буюу тодруулах шаардлагатай байж болно.

## **Худалдан авалтын тайлагнал**

*Сөрөг худалдан авалт*

МЗУ66. Үнэт цаас гаргаж буй байгууллага (хууль ёсны нэгтгэгч)-ыг МЗУ10-МЗУ18-р параграфт заасан заавар удирдамжид үндэслэн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор худалдан авсан үйл ажиллагаа гэж тодорхойлсон тохиолдолд сөрөг худалдан авалт үүсдэг. Харин өмчийн хувь оролцоогоо зарж эзэмшүүлж буй байгууллага (хууль ёсны худалдан авсан үйл ажиллагаа) нь сөрөг худалдан авалт гэж үзэх ажил гүйлгээний хувьд нягтлан бодох бүртгэлийн зорилгоор нэгтгэгч байх ёстой. Жишээлбэл; улсын секторын байгууллага нь биржид бүртгэлтэй байгууллага болохыг хүссэн боловч өөрийн өмчийн хувьцааг биржид гаргахыг хүсээгүй тохиолдолд зарим үед сөрөг худалдан авалт үүсдэг. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд тухайн улсын секторын байгууллага нь биржид бүртгэлтэй компанийн өмчийн хувь оролцооны арилжаа хийж, түүний өмчийн хувь оролцоог олж эзэмшихийн тулд уг биржид бүртгэлтэй компанитай хэлцэл хийнэ. Энэ жишээнд, биржид бүртгэлтэй

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

компани нь өөрийн өмчийн хувь оролцоог гаргасан тул хууль ёсны нэгтгэгч болно, харин улсын секторын байгууллага нь түүний өмчийн хувь оролцоог олж эзэмшсэн тул хууль ёсны худалдан авсан үйл ажиллагаа болно. Гэвч МЗУ10-МЗУ18-р параграфт заасан заавар удирдамжийг мөрдсөнөөр дараах байдлаар тодорхойлно:

- (а) Уг биржид бүртгэлтэй компанийг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор тухайн худалдан авсан үйл ажиллагаа (нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагаа) гэж тодорхойлох - өөрөөр хэлбэл, биржид бүртгэлтэй компани нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авахгүй;
- (б) Тус улсын секторын байгууллагыг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор нэгтгэгч (нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгч) гэж тодорхойлох - өөрөөр хэлбэл, улсын секторын байгууллага нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авахгүй.

Нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагаа нь сөрөг худалдан авалт гэж тайлагнах тухайн ажил гүйлгээний хувьд үйл ажиллагааны тодорхойлолтыг хангах бөгөөд энэ Стандартад заасан хүлээн зөвшөөрөлтийн болон хэмжилтийн бүх зарчмууд, үүн дотроо гүүдвилийг хүлээн зөвшөөрөх шаардлагыг даган мөрдөх ёстой.

### Шилжүүлсэн төлбөрийг хэмжих

МЗУ67. Сөрөг худалдан авалтын үед нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгч нь худалдан авсан үйл ажиллагаанд ихэвчлэн төлбөр төлдөггүй. Харин нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагаа нь уг нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн эздэд ихэвчлэн өөрийн өмчийн хувьцааг гаргаж өгдөг. Иймээс нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагаа дахь өөрийн өмчийн хувь оролцооны хариуд нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн шилжүүлсэн төлбөрийн тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ нь сөрөг худалдан авалтын үр дүнд уг нэгдсэн байгууллагад эзэмших өмчийн хувь оролцоотой ижил хувь хэмжээгээр хууль ёсны хяналт тавигч байгууллагын эздэд өгөхийн тулд тэрхүү хууль ёсны хяналтанд буй байгууллагын гаргах байсан өмчийн хувь оролцооны тоонд үндэслэнэ. Ингэж тооцоолсон өмчийн хувь оролцооны бодит үнэ цэнийг уг худалдан авсан үйл ажиллагаатай хийсэн арилжаагаар шилжүүлсэн төлбөрийн бодит үнэ цэнэ болгон ашиглаж болох юм.

### Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх ба толилуулах

МЗУ68. Сөрөг худалдан авалтын дараа бэлтгэсэн, нэгтгэсэн санхүүгийн тайланг хууль ёсны хяналт тавигч байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагааны) нэрээр гаргах боловч тухайн нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагааны хууль ёсны капиталыг тусгахын тулд нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн хууль ёсны капиталыг буцаах горимоор залруулах нэг тохируулгын хамтаар энэ нь уг хууль ёсны хяналтанд буй байгууллагын (нягтлан бодох

бүртгэлийн нэгтгэгчийн) санхүүгийн тайлангийн үргэлжлэл гэдгийг тэрхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгад тусгана. Хууль ёсны хяналт тавигч байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагааны) капиталыг тусгахын тулд ийм тохируулга хийх шаардлагатай байдаг. Хууль ёсны хяналт тавигч байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагааны) хууль ёсны капиталыг тусгахын тулд тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд толилуулсан зэрэгцүүлэгдэх мэдээллийг мөн буцаах горимоор залруулна.

МЗУ69. Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь капиталын бүтцээс бусад зүйлсийн хувьд уг хууль ёсны хяналтанд буй байгууллагын санхүүгийн тайлангийн үргэлжлэл байх тул тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах зүйлсийг тусгана:

- (а) Нэгдлийн өмнөх дансны үнээр хүлээн зөвшөөрч, хэмжсэн уг хууль ёсны хяналтанд буй байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн) хөрөнгө ба өр төлбөр.
- (б) Энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжсэн уг хууль ёсны хяналт тавигч байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагааны) хөрөнгө ба өр төлбөр.
- (в) Худалдан авалтын өмнөх уг хууль ёсны хяналтанд буй байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн) хуримтлагдсан ашиг, алдагдал ба бусад өмчийн үлдэгдэл.
- (г) Худалдан авалтын яг өмнө эргэлтэнд байгаа уг хууль ёсны хяналтанд буй байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн) гаргасан өмчийн хувь оролцоог хууль ёсны хяналт тавигч байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагааны) бодит үнэ цэнэ дээр нэмснээр тодорхойлж, тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан өмчийн хувь оролцоо байдлаар хүлээн зөвшөөрсөн дүн. Гэвч өмчийн бүтэц (өөрөөр хэлбэл, гаргасан өмчийн хувь оролцооны тоо ба төрөл) нь хууль ёсны хяналт тавигч байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагааны) өмчийн бүтцийг, үүн дотроо уг худалдан авалтыг хийхийн тулд хууль ёсны хяналт тавигч байгууллагын гаргасан өмчийн хувь оролцоог тусгадаг. Иймээс сөрөг худалдан авалтаар гаргасан, хууль ёсны хяналт тавигч байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагааны) хувьцааны тоог тусгахын тулд тэрхүү худалдан авалтын гэрээнд заасан, арилжааны харьцааг ашигласнаар уг хууль ёсны хяналтанд буй байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн) өмчийн бүтцийг дахин тайлагнана.
- (д) Уг хууль ёсны хяналтанд буй байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн) хуримтлагдсан ашиг ба бусад өмчийн хувь оролцооны тухайн худалдан авалтаас өмнөх дансны үнэ дэх хяналтын бус хувь оролцооны хувь тэнцүүлсэн хэмжээ. Үүнийг МЗУ70 ба МЗУ71-р параграфт авч хэлэлцсэн.

Хяналтын бус хувь оролцоо

- МЗУ70. Сөрөг худалдан авалтын хувьд, хууль ёсны худалдан авсан үйл ажиллагааны (нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн) зарим эзэд нь өөрсдийн өмчийн хувь оролцоог тухайн хууль ёсны хяналт тавигч байгууллагын (нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагааны) өмчийн хувь оролцоогоор арилжихгүй байж болох юм. Тэдгээр эздийг уг сөрөг худалдан авалтын дараах тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд хяналтын бус хувь оролцоо гэж үздэг. Яагаад гэвэл, хууль ёсны нэгтгэгчийн өмчийн хувь оролцоогоор өөрсдийн өмчийн хувь оролцоог арилжаагүй, уг хууль ёсны худалдан авсан үйл ажиллагааны эзэд нь тухайн нэгдсэн байгууллагын үр дүн ба цэвэр хөрөнгөнд биш, харин хууль ёсны худалдан авсан үйл ажиллагааны үр дүн ба цэвэр хөрөнгөнд зөвхөн хувь оролцоотой байдаг. Эсрэгээр, хууль ёсны нэгтгэгч нь нягтлан бодох бүртгэлийн зорилгоор худалдан авсан үйл ажиллагаа боловч хууль ёсны нэгтгэгчийн эзэд нь тухайн нэгдсэн байгууллагын үр дүн ба цэвэр хөрөнгөнд хувь оролцоотой байдаг.
- МЗУ71. Хууль ёсны худалдан авсан үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн уг нэгдлээс өмнөх дансны үнээр тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд хэмжиж, хүлээн зөвшөөрдөг (МЗУ69(а) параграфыг үзнэ үү). Иймээс хэдийгээр бусад худалдан авалтын хувьд хяналтын бус хувь оролцоог уг худалдан авалтын өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмждэг боловч сөрөг худалдан авалтын үед хяналтын бус хувь оролцоо нь хууль ёсны худалдан авсан үйл ажиллагааны тухайн худалдан авалтын өмнөх дансны үнэ дэх тэдгээр хяналтын бус хувьцаа эзэмшигчдийн хувь тэнцүүлсэн хувь оролцоог тусгадаг.

*Худалдан авалтаар олж эзэмшсэн тухайн тодорхой хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх (64-68-р параграфыг үзнэ үү)*

Үйл ажиллагааны түрээс

- МЗУ72. МЗУ73-МЗУ74-р параграфт шаардсанаас бусад тохиолдолд худалдан авсан үйл ажиллагаа нь түрээслэгч байх үйл ажиллагааны түрээстэй холбоотойгоор нэгтгэгч нь хөрөнгө буюу өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй.
- МЗУ73. Худалдан авсан үйл ажиллагаа нь түрээслэгч байх үйл ажиллагааны түрээс тус бүрийн нөхцөл нь тааламжтай эсвэл тааламжгүй эсэхийг нэгтгэгч нь тодорхойлно. Үйл ажиллагааны түрээсийн нөхцөл нь зах зээлийн нөхцөлтэй харьцуулахад тааламжтай байвал нэгтгэгч нь биет бус хөрөнгийг, харин зах зээлийн нөхцөлтэй харьцуулахад тааламжгүй бол өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Худалдан авсан үйл ажиллагаа нь түрээслүүлэгч байх үйл ажиллагааны түрээст хамаарах хөрөнгийн тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг хэмжих талаархи заавар удирдамжийг МЗУ89-р параграфт тусгасан.
- МЗУ74. Тодорхойлогдох биет бус хөрөнгө нь үйл ажиллагааны түрээстэй холбоотой байж болох бөгөөд түүнийг зах зээлийн нөхцлөөр хийдэг

байлаа ч гэсэн тухайн түрээсийн хувьд үнийг уг зах зээлийн оролцогчдын бэлэн боломжтой байдлаар ийм холбоотой эсэхийг нотолж болох юм. Тухайлбал; нисэх онгоцны буудал дахь үүдэн хэсэг эсвэл худалдааны гол байршилд жижиглэн худалдаа эрхлэх талбай түрээслэх нь зах зээлд буюу ирээдүйн эдийн засгийн бусад үр өгөөж болон үйлчилгээний чадавхид хандан нэвтрэх боломж бүрдүүлдэг бөгөөд энэ нь жишээлбэл, үйлчилгээний хэрэглэгчтэй тогтоосон харилцаа гэх мэт тодорхойлогдох биет бус хөрөнгийн шалгуурыг хангах юм. Энэ тохиолдолд нэгтгэгч нь холбогдох уг тодорхойлогдох биет бус хөрөнгө (хөрөнгүүд)-ийг МЗУ75-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө.

#### Биет бус хөрөнгө

МЗУ75. Нэгтгэгч нь худалдан авалтаар олж эзэмшсэн тодорхойлогдох биет бус хөрөнгийг гүүдвилээс тусад нь хүлээн зөвшөөрнө. Биет бус хөрөнгө нь салган тусгаарлаж болох эсвэл заавал биелүүлэх хэлцлээс үүссэн байх гэсэн хоёр шалгуурын аль нэгийг хангадаг бол тодорхойлогдох боломжтой байна.

МЗУ76. Биет бус хөрөнгө нь худалдан авсан үйл ажиллагаанаас эсвэл бусад эрх, үүргээс салган тусгаарлах буюу шилжүүлэх боломжгүй байлаа ч гэсэн заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангадаг биет бус хөрөнгө нь тодорхойлогдох боломжтой байна. Тухайлбал;

- (а) Худалдан авсан үйл ажиллагаа нь зах зээлийн нөхцөлтэй харьцуулахад тааламжтай тийм нөхцөл бүхий үйл ажиллагааны түрээсээр байгууламжийг түрээсэлдэг. Тухайн түрээсийн нөхцөл нь уг түрээсийг (борлуулалт эсвэл дамжуулан түрээс байдлаар) шилжүүлэхийг шууд хориглодог. Нэгтгэгч нь тухайн түрээсийн гэрээг борлуулах буюу бусад байдлаар шилжүүлэх боломжгүй боловч ижил буюу адилтгах зүйлсийн хувьд одоогийн зах зээлийн ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулахад тааламжтай тийм түрээсийн нөхцлөөр тооцох дүн нь гүүдвилээс тусдаа хүлээн зөвшөөрөх уг заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангах биет бус хөрөнгө юм.
- (б) Худалдан авсан үйл ажиллагаа нь цөмийн эрчим хүчний цахилгаан станцыг өмчилж, ажиллуулдаг. Хэдийгээр нэгтгэгч нь цахилгаан станцыг ажиллуулах лицензийг тэрхүү олж эзэмшсэн цахилгаан станцаас тусад нь борлуулах буюу шилжүүлэх боломжгүй боловч уг лиценз нь гүүдвилээс тусдаа хүлээн зөвшөөрөх талаархи тухайн заавал биелүүлэх гэрээний дагуу үүсэх хууль ёсны шалгуурыг хангадаг биет бус хөрөнгө юм. Ажиллуулах лиценз ба цахилгаан станцын ашиглалтын хугацаа нь ижил төсөөтэй бол нэгтгэгч нь санхүүгийн тайлагналын зорилгоор тэдгээр хөрөнгүүдийг бодит үнэ цэнээр нь нэг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрч болох юм.
- (в) Худалдан авсан үйл ажиллагаа нь технологийн патентыг өмчилдөг. Тухайн худалдан авсан үйл ажиллагаа нь зөвхөн

дотоодын зах зээлээс гадуур ашиглах нөхцөлтэйгээр уг патентыг бусдад лицензээр ашиглуулж, үүний хариуд ирээдүйн гадаад орлогоос тохиролцсон хувийг авдаг. Хэдийгээр технологийн патент ба холбогдох лицензийн гэрээг нэг нэгнээс нь тусдаа борлуулах буюу арилжих практик боломжгүй боловч уг патент ба лицензийн гэрээний аль аль нь гүүдвилээс тусдаа хүлээн зөвшөөрөх, тухайн заавал биелүүлэх хэлцлийн дагуу үүсэх хууль ёсны шалгуурыг хангах юм.

МЗУ77. Салган тусгаарлаж болох гэдэг нь тухайн олж эзэмшсэн биет бус хөрөнгийг худалдан авсан үйл ажиллагаанаас салгах буюу хуваах түүнчлэн, дангаар нь, эсвэл холбогдох заавал биелүүлэх хэлцэл, тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн хамтаар борлуулах, шилжүүлэх, төлбөртэйгээр ашиглуулах, түрээслэх, арилжих боломжтой байхыг хэлнэ. Нэгтгэгч нь борлуулах, төлбөртэйгээр ашиглуулах буюу үнэ цэнэ бүхий өөр зүйлээр бусад ямар нэг байдлаар арилжиж болох биет бус хөрөнгө нь хэдийгээр тухайн борлуулагч түүнийг борлуулах, төлбөртэйгээр ашиглуулах буюу салган тусгаарлах шалгуурыг хангах юм. Тухайн төрлийн хөрөнгийн эсвэл ижил төсөөтэй хөрөнгийн арилжааны ажил гүйлгээний талаархи нотолгоо байгаа бол хэдийгээр ийм ажил гүйлгээ байнга гардаггүй ч гэсэн, мөн тухайн нэгтгэгч тийм ажил гүйлгээнд оролцсон эсэхээс үл хамааран олж эзэмшсэн биет бус хөрөнгө нь салган тусгаарлаж болох шалгуурыг хангана. Жишээлбэл; үйлчлүүлэгчдийн жагсаалтыг байнга төлбөртэйгээр ашиглуулдаг тул энэ нь салган тусгаарлаж болох шалгуурыг хангана. Нэгдэгч нь өөрийн үйлчлүүлэгчдийн жагсаалтыг бусад байгууллагын үйлчлүүлэгчдийн жагсаалтаас ялгарах шинж чанартай гэж үздэг тохиолдолд түүний үйлчлүүлэгчдийн жагсаалтыг байнга төлбөртэйгээр ашиглуулж байгаа нь уг олж эзэмшсэн худалдан авагчийн жагсаалт салган тусгаарлах шалгуурыг хангана гэсэн утгыг ерөнхийдөө илэрхийлнэ. Гэвч нууц хадгалах буюу бусад гэрээ хэлцлийн нөхцөл нь өөрийн үйлчлүүлэгчдийн талаархи мэдээллийг борлуулах, түрээслүүлэх буюу бусад байдлаар арилжихыг байгууллагад хориглодог бол худалдан авалтаар олж эзэмшсэн үйлчлүүлэгчдийн жагсаалт нь салган тусгаарлах шалгуурыг хангахгүй юм.

МЗУ78. Худалдан авсан үйл ажиллагаанаас буюу нэгдсэн байгууллагаас бие даасан байдлаар салган тусгаарлах боломжгүй биет бус хөрөнгө нь холбогдох заавал биелүүлэх хэлцэл, тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөртэй нэгдсэнээр салган тусгаарлаж болохоор бол энэ нь салган тусгаарлах шалгуурыг хангах юм. Тухайлбал, худалдан авсан үйл ажиллагаа нь бүртгүүлсэн худалдааны тэмдэг ба уг худалдааны тэмдэг бүхий бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашигласан, баримтжуулсан боловч патентжуулаагүй техникийн мэдлэг, чадварыг өмчилдөг. Худалдааны тэмдгийн өмчлөлийг шилжүүлэхийн тулд тухайн өмчлөгч нь өөрийн үйлдвэрлэж байсан бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд уг шинэ өмчлөгчид шаардлагатай аливаа бусад зүйлсийг мөн шилжүүлэх шаардлагатай байдаг. Хэрэв холбогдох худалдааны

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

тэмдгийг борлуулвал уг патентжуулаагүй техникийн мэдлэг, чадварыг тухайн худалдан авсан үйл ажиллагаа буюу нэгдсэн байгууллагаас салган тусгаарлах ба борлуулах учраас энэ нь салган тусгаарлах шалгуурыг хангах юм.

### Дахин олж эзэмшсэн эрх

МЗУ79. Нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн эсвэл хүлээн зөвшөөрөөгүй нэг буюу хэд хэдэн хөрөнгүүдийг ашиглах талаар уг худалдан авсан үйл ажиллагаанд өмнө олгосон эрхийг нэгтгэгч нь худалдан авалтын нэг хэсэг байдлаар дахин олж эзэмшиж болох юм. Ийм эрхийн жишээнд технологийн лицензийн гэрээний дагуу нэгтгэгчийн технологийг ашиглах эрх хамаарна. Дахин олж эзэмшсэн эрх нь нэгтгэгч түүнийг тохиролцоот худалдан авалтын гүүдвил буюу олзоос тусдаа хүлээн зөвшөөрдөг, тодорхойлогдох биет бус хөрөнгө юм. Дахин олж эзэмшсэн эрхийг хэмжих заавар удирдамжийг 83-р параграфт, уг дахин олж эзэмшсэн эрхийн дараагийн тайлант үеийн тайлагналын талаархи заавар удирдамжийг 113-р параграфт тусгасан.

МЗУ80. Дахин олж эзэмшсэн эрх үүсэхэд хүргэх гэрээний нөхцлүүд нь ижил буюу төсөөтэй зүйлстэй холбоотой одоогийн зах зээлийн ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулахад тааламжтай эсвэл тааламжгүй бол нэгтгэгч нь барагдуулалтын олз, гарзыг хүлээн зөвшөөрнө. Барагдуулалтын олз, гарзыг хэмжих талаархи заавар удирдамжийг МЗУ100-р параграфт заасан.

### Бүрдүүлсэн ажиллах хүч ба тодорхойлогдох боломжгүй бусад зүйлс

МЗУ81. Нэгтгэгч нь тодорхойлогдох боломжгүй, уг олж эзэмшсэн биет бус хөрөнгийн үнэ цэнийг тухайн худалдан авалтын өдрөөр гүүдвилд нэгтгэн оруулдаг. Тухайлбал; нэгтгэгч нь худалдан авсан үйл ажиллагаагаа тухайн худалдан авалтын өдрөөс хойш үргэлжлүүлэн ажиллуулах боломжийг түүнд олгох одоогийн ажилтнуудын баг болох уг бүрдүүлсэн ажиллах хүчний оршин байдалд үнэ цэнэ хамааруулж болох юм. Бүрдүүлсэн ажиллах хүч нь ур чадвартай ажиллах хүчний оюуны капиталыг, өөрөөр хэлбэл уг худалдан авсан үйл ажиллагааны ажиллах хүчин өөрсдийн ажилдаа бий болгох (ихэвчлэн мэргэшсэн) мэдлэг, туршлагыг төлөөлөн илэрхийлэхгүй. Бүрдүүлсэн ажиллах хүч нь тохиролцоот худалдан авалтын гүүдвил болон олзоос тусдаа хүлээн зөвшөөрөх, тодорхойлогдох хөрөнгө биш учраас түүнд хамаарах аливаа үнэ цэнийг тохиролцоот худалдан авалтын гүүдвил буюу олзод шингээн тусгадаг.

МЗУ82. Нэгтгэгч нь тухайн худалдан авалтын өдрөөр хөрөнгийн шалгуурыг хангахгүй зүйлсэд хамаарах аливаа үнэ цэнийг мөн тохиролцоот худалдан авалтын гүүдвилд буюу олзод шингээн тусгана. Тухайлбал; худалдан авсан үйл ажиллагаа нь тухайн худалдан авалтын өдөр боломжит шинэ худалдан авагч нартай хэлэлцэн тохирч болох тийм биелүүлэх хэлцлийн хувьд нэгтгэгч нь үнэ цэнэ хамааруулж болох юм.



## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

Тийм боломжит заавал биелүүлэх хэлцлүүд нь худалдан авалтын өдрөөр хөрөнгө биш тул нэгтгэгч нь тэдгээрийг тохиролцоот худалдан авалтын гүүдвил болон олзоос тусдаа хүлээн зөвшөөрөхгүй. Нэгтгэгч нь тухайн худалдан авалтын өдрийн дараа гарч тохиолдсон үйл явдлын хувьд тэдгээр заавал биелүүлэх хэлцлийн үнэ цэнийг дараагийн тайлант үед гүүдвилээс салган дахин ангилахгүй. Гэвч нэгтгэгч нь тусдаа хүлээн зөвшөөрч болох биет бус хөрөнгө уг худалдан авалтын өдрөөр оршин байсан эсэхийг тодорхойлохын тулд тэрхүү худалдан авалтын дараахан гарч тохиолдсон үйл явдлуудын талаархи баримт материал болон нөхцөл байдлуудыг үнэлэх хэрэгтэй.

МЗУ83. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, нэгтгэгч нь худалдан авалтаар олж эзэмшсэн биет бус хөрөнгүүдийг УСНББОУС 31-ийн дагуу тайлагнана. Харин УСНББОУС 31-ийн 6-р параграфт дурдсанчлан, олж эзэмшсэн зарим биет бус хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах тайлагналыг бусад УСНББОУС-уудад заасан байдаг.

МЗУ84. Тодорхойлогдох байдлын шалгуур нь биет бус хөрөнгийг гүүдвилээс тусад нь хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлдог. Гэвч энэ шалгуур нь биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжих заавар удирдамжаар ч хангахгүй, мөн бодит үнэ цэнийг хэмжихэд ашиглах таамаглалуудыг хязгаарлах ч үгүй юм. Тухайлбал; биет бус хөрөнгийн үнийг тогтоох үедээ зах зээлийн оролцогчдын ашигладаг тухайн заавал биелүүлэх хэлцлийг ирээдүйд шинэчлэн сунгах хүлээлт гэх мэт таамаглалуудыг уг нэгтгэгч нь бодит үнэ цэнийг хэмжихдээ харгалзан үзнэ. Хэлцлийн ийм шинэчлэн сунгалт нь тодорхойлогдох байдлын шалгуурыг өөрөө заавал хангах албагүй юм (Харин худалдан авалтаар хүлээн зөвшөөрсөн, уг дахин олж эзэмшсэн эрхийн хувьд бодит үнэ цэнийн хэмжилтийн зарчмын гажих нөхцлийг 83-р параграфт заасан, үүнийг үзнэ үү). Биет бус хөрөнгийг бусад биет болон биет бус хөрөнгийн хамтаар дансны нэг нэгжид нэгтгэн тусгах эсэхийг тодорхойлох талаархи заавар удирдамжийг УСНББОУС 31-ийн 39Г ба 39Д параграфт заасан.

*Төлөх ёстой татварыг худалдан авалтын үр дүнд чөлөөлөх (тухайн худалдан авалтын нөхцөлд тусгасан тохиолдолд) (78-79-р параграфыг үзнэ үү)*

МЗУ85. Нэгдэгч үйл ажиллагааны төлөх ёстой татварыг тухайн худалдан авалтын нөхцлийн нэг хэсэг байдлаар татварын эрх бүхий байгууллагаас чөлөөлсөн тохиолдолд нэгтгэгч нь үүнтэй холбоотойгоор ямар нэг дүнг хүлээн зөвшөөрөхгүй. Худалдан авалтын дараа татвараас чөлөөлсөн тохиолдолд тухайн үр дүнгийн байгууллага нь 118-р параграфын шаардлагуудыг даган мөрдөнө. Худалдан авсан үйл ажиллагааны төлөх ёстой бөгөөд татварын эрх бүхий байгууллагаас чөлөөлөөгүй татварыг уг нэгтгэгч нь орлогын албан татварыг зохицуулдаг, нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу тайлагнана.

МЗУ86. Нэгтгэгч нь өөрөө татварын эрх бүхий байгууллага бол тус байгууллага нь уг нэгдэгч үйл ажиллагааны төлөх ёстой боловч чөлөөлөгдсөн

татвартай холбоотой аливаа татварын авлагыг УСНББОУС 23-ын дагуу үл хүлээн зөвшөөрнө.

МЗУ87. Татварын эрх бүхий байгууллага нь нэгтгэгчийн төлөх ёстой татварыг уг худалдан авалтын нөхцлийн үр дүнд чөлөөлсөн бол нэгтгэгч нь орлогын албан татварыг зохицуулдаг, нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу тэрхүү дүнг тайлагнана.

*Худалдан авалтын үед тухайн тодорхойлогдох хөрөнгө ба худалдан авсан үйл ажиллагаан дахь хяналтын бус хувь оролцооны бодит үнэ цэнийг хэмжих (72-73-р параграфыг үзнэ үү)*

Тодорхой бус мөнгөн гүйлгээ бүхий хөрөнгө (үнэлгээний хасагдуулга)

МЗУ88. Худалдан авалтаар олж эзэмшсэн хөрөнгүүдийн ирээдүйн мөнгөн гүйлгээний тодорхой бус байдлын үр нөлөөг бодит үнэ цэнийн хэмжилтэнд тусган оруулдаг учраас тухайн худалдан авалтын өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмждэг хөрөнгүүдийн хувьд нэгтгэгч нь уг худалдан авалтын өдрөөр үнэ цэнийн бууралтын тусдаа хасагдуулга хүлээн зөвшөөрөхгүй. Жишээлбэл; энэ Стандарт нь худалдан авалтыг тайлагнахдаа тухайн олж эзэмшсэн авлага, үүн дотроо зээлийг уг худалдан авалтын өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмжихийг нэгтгэгчээс шаарддаг тул нэгтгэгч нь тэрхүү өдрөөр үл цуглуулагдах гэж төсөөлсөн учраас заавал биелүүлэх хэлцлийн мөнгөн гүйлгээний хувьд үнэ цэнийн бууралтын тусдаа хасагдуулга хүлээн зөвшөөрөхгүй.

Худалдан авсан үйл ажиллагаа нь түрээслүүлэгч байх үйл ажиллагааны түрээст хамаарах хөрөнгө

МЗУ89. Худалдан авсан үйл ажиллагаа нь түрээслүүлэгч байх үйл ажиллагааны түрээсийн зүйл болох барилга гэх мэт хөрөнгийн тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг хэмжихдээ, нэгтгэгч нь түрээсийн нөхцлийг харгалзан үзнэ. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагааны түрээсийн нөхцөл нь зах зээлийн нөхцөлтэй харьцуулахад тааламжтай эсвэл тааламжгүй тохиолдолд худалдан авсан үйл ажиллагаа нь түрээслэгч байх тийм түрээсийн хувьд МЗУ73-р параграфтаар шаарддагтай адилаар нэгтгэгч нь тусдаа хөрөнгө эсвэл өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

Нэгтгэгч нь ашиглахгүй байх эсвэл зах зээлийн бусад оролцогчдын ашигладаг арга замаас өөр арга замаар ашиглах зорилготой байгаа хөрөнгө

МЗУ90. Өөрийн өрсөлдөөний байр сууриа хамгаалах буюу бусад учир шалтгаанаар нэгтгэгч нь уг олж эзэмшсэн санхүүгийн бус хөрөнгөө идэвхитэй ашиглахгүй байх санаа зорилготой эсвэл тухайн хөрөнгийг хамгийн өндөр болон хамгийн сайн боломжоор ашиглах санаа зорилгогүй байж болох юм. Жишээлбэл; нэгтгэгч нь өөр бусад талууд түүнийг ашиглахаас сэргийлж, хамгаалалтын зориулалтаар ашиглахаар төлөвлөн, олж эзэмшсэн судалгаа ба хөгжүүлэлтийн биет бус хөрөнгийн хувьд ийм тохиолдол үүсэж болно. Гэхдээ уг санхүүгийн бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх, түүнчлэн дараагийн тайлант үед

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

үнэ цэнийн бууралтыг сорьж шалгахын тулд данснаас хасах зардлыг хассан бодит үнэ цэнийг хэмжихдээ, нэгтгэгч нь зах зээлийн оролцогч нар тухайн хөрөнгийг хамгийн өндөр болон хамгийн сайн боломжоор ашиглана гэж үзээд түүний бодит үнэ цэнийг зохих үнэлээний урьдчилсан нөхцлийн дагуу хэмжинэ.

Худалдан авсан үйл ажиллагаан дахь хяналтын бус хувь оролцоо

МЗУ91. Энэ Стандарт нь худалдан авсан үйл ажиллагаан дахь хяналтын бус хувь оролцоог нэгтгэгч тухайн худалдан авалтын өдрөөрх түүний бодит үнэ цэнээр хэмжихийг зөвшөөрдөг. Зарим тохиолдолд нэгтгэгч нь уг өмчийн хувьцааны (өөрөөр хэлбэл, тухайн нэгтгэгч эзэмшдэггүй хувьцааны) идэвхитэй зах зээл дэх жишиг үнэд үндэслэн хяналтын бус хувь оролцооны тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг хэмжих боломжтой байдаг. Харин өөр зарим тохиолдолд уг өмчийн хувьцааны идэвхитэй зах зээлийн жишиг үнэ бэлэн боломжтой байдаггүй. Ийм тохиолдолд нэгтгэгч нь бусад үнэлгээний арга зүйг ашигласнаар уг хяналтын бус хувь оролцооны бодит үнэ цэнийг хэмжинэ.

МЗУ92. Худалдан авсан үйл ажиллагаан дахь нэгтгэгчийн хувь оролцооны болон нэгж хувьцаанд үндэслэсэн хяналтын бус хувь оролцооны бодит үнэ цэнүүд нь хоорондоо өөр байж болох юм. Хэрэв хяналтын бус хувь оролцооны үнийг тогтоохдоо зах зээлийн оролцогч нар нь хяналтын эрхийн урамшуулал эсвэл хяналтын бус эрхийн хөнгөлөлтийг харгалзан үздэг бол гол зөрүү нь худалдан авсан үйл ажиллагаан дахь уг нэгтгэгчийн хувь оролцооны нэгж хувьцаанд ногдох бодит үнэ цэнэд хяналтын урамшууллыг оруулснаар эсвэл эсрэгээр, хяналтын бус хувь оролцооны нэгж хувьцаанд ногдох бодит үнэ цэнэд хяналтгүй байдлын хөнгөлөлтийг (хяналтын бус хувь оролцооны хөнгөлөлт гэж бас нэрлэдэг) оруулснаар үүсэх магадлалтай байдаг.

*Худалдан авалтын үед тохиролцоот худалдан авалтаас үүсэх гүүдвил буюу олзыг хэмжих (85-98-р параграфыг үзнэ үү)*

Гүүдвил ба мөнгөн гүйлгээний хоорондох холбоо (86-р параграфыг үзнэ үү)

МЗУ93. Нэгтгэгч нь нэмэгдсэн мөнгөн орлогын гүйлгээ эсвэл буурсан мөнгөн зарлагын гүйлгээний үр дүнд түүний цэвэр мөнгөн гүйлгээнд тааламжтай өөрчлөлт гарна гэж тооцоолсон зөвхөн тэр хэмжээгээр гүүдвیلیйг хүлээн зөвшөөрнө. Нэгтгэгч нь мөнгөн гүйлгээнээс бусад үйлчилгээний чадавхитай холбоотойгоор гүүдвیلیйг хүлээн зөвшөөрөхгүй.

Худалдан авсан үйл ажиллагаан дахь нэгтгэгчийн хувь оролцооны тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг үнэлгээний арга зүй ашиглан хэмжих (87-р параграфыг үзнэ үү)

МЗУ94. Төлбөр шилжүүлэхгүйгээр хийгдсэн худалдан авалтын хувьд, нэгтгэгч нь тохиролцоот худалдан авалтаас үүсэх гүүдвил, гарз буюу олзыг хэмжихийн тулд уг шилжүүлэх төлбөрийн тухайн худалдан авалтын

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

өдрөөрх бодит үнэ цэнийн оронд худалдан авсан үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцооны тэрхүү худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг ашиглах ёстой (85-87-р параграфыг үзнэ үү).

Хамтын байгууллагуудын нэгдэлд худалдан авалтын аргыг хэрэглэхэд тусгайлан анхаарах зүйлс (87-р параграфын мөрдөлт)

МЗУ95. Хоёр хамтын байгууллага нэгдэх тохиолдолд, худалдан авсан үйл ажиллагаан дахь өмчийн буюу гишүүдийн хувь оролцооны бодит үнэ цэнэ (эсвэл худалдан авсан үйл ажиллагааны бодит үнэ цэнэ) нь уг нэгтгэгчийн шилжүүлсэн гишүүдийн хувь оролцооны бодит үнэ цэнээс илүү найдвартайгаар хэмжигдэх боломжтой байж болно. Энэ тохиолдолд төлбөр болгон шилжүүлсэн нэгтгэгчийн өмчийн хувь оролцооны тухайн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг биш, харин худалдан авсан үйл ажиллагааны өмчийн хувь оролцооны тэрхүү худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг ашигласнаар нэгтгэгч нь гүүдвилийн дүнг тодорхойлохыг 87-р параграфтаар шаардсан байдаг. Түүнчлэн, хамтын байгууллагуудын нэгдлийн үед, нэгтгэгч нь худалдан авалтын аргыг бусад төрлийн байгууллагууд мөрддөг арга замд нийцүүлэн тухайн худалдан авсан үйл ажиллагааны цэвэр хөрөнгийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа хуримтлагдсан ашиг, алдагдлын нэмэгдэлт байдлаар биш, харин капитал буюу өмчийн шууд нэмэгдэлт байдлаар хүлээн зөвшөөрнө.

МЗУ96. Хэдийгээр бусад байгууллагуудтай олон талаар ижил төсөөтэй боловч хамтын байгууллагын гишүүд нь худалдан авагч ба эзний аль аль нь болдог учраас үүнээс юуны өмнө хамааран хамтын байгууллагууд нь эрс өөр онцлог шинж чанартай байдаг. Хамтын байгууллагуудын гишүүд нь ихэвчлэн бараа, үйлчилгээний төлбөрийн хямдруулалт эсвэл халамжийн ногдол ашиг хэлбэрээр өөрийн гишүүнчлэлийн өгөөжийг авахаар ерөнхийдөө хүлээж байдаг. Гишүүн бүрд хуваарилах халамжийн ногдол ашгийн хувь хэсэг нь тайлант жилийн туршид уг байгууллагатай тухайн гишүүний хийсэн бизнесийн дүнд ихэвчлэн үндэслэдэг.

МЗУ97. Хамтын байгууллагын бодит үнэ цэнийн хэмжилт нь гишүүдийн ирээдүйн өгөөжийн талаар зах зээлийн оролцогчдын хийх таамаглал, түүнчлэн уг хамтын байгууллагын талаар зах зээлийн оролцогчдын хийх холбогдох бусад аливаа таамаглалыг тусгасан байвал зохино. Жишээлбэл; хамтын байгууллагын бодит үнэ цэнийг хэмжихийн тулд өнөөгийн үнэ цэнийн арга зүйг ашиглаж болох юм. Ийм загварт орц болгон ашигласан мөнгөн гүйлгээ нь уг хамтын байгууллагын хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнд үндэслэх бөгөөд бараа, үйлчилгээний төлбөрийн хямдруулалт гэх мэт гишүүдийн өгөөжид зориулсан бууралтыг тусгах магадлалтай байдаг.

*Худалдан авалтын ажил гүйлгээний нэг хэсэг болох эсэхийг тодорхойлох (109-111-р параграфыг үзнэ үү)*

МЗУ98. Ажил гүйлгээ нь худалдан авсан үйл ажиллагааг авах арилжааны нэг хэсэг эсвэл тухайн арилжаа нь худалдан авалтаас тусдаа эсэхийг тодорхойлохын тулд нэгтгэгч нь харилцан бие биенээ үгүйсгэдэг ч үгүй, дангаараа дүгнэлтийн шинжтэй ч байдаггүй дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй:

- (а) Ажил гүйлгээ гарах болсон шалтгаан. Худалдан авалтын оролцогч талууд (нэгтгэгч ба худалдан авсан үйл ажиллагаа, түүнчлэн тэдний эзэд, захирлууд ба менежерүүд - тэдний итгэмжлэгдсэн этгээд) тухайн ажил гүйлгээ буюу хэлцлийг хийсэн шалтгааныг мэдэх нь тэрхүү ажил гүйлгээ худалдан авалтын зорилгоор шилжүүлсэн төлбөр, олж эзэмшсэн хөрөнгө, хариуцсан үүргийн нэг хэсэг мөн эсэх талаар ойлголт өгч болох юм. Тухайлбал; ажил гүйлгээг юуны өмнө тухайн нэгдлийн өмнөх уг худалдан авсан үйл ажиллагаа буюу түүний хуучин эздийн ашиг тусын төлөө биш, харин нэгтгэгчийн болон нэгдсэн байгууллагын ашиг тусын төлөө хийсэн бол төлсөн ажил гүйлгээний үнийн тэрхүү хэсэг (болон холбогдох аливаа хөрөнгө буюу өр төлбөр) нь худалдан авсан үйл ажиллагааг авах арилжааны нэг хэсэг болох магадлал бага байдаг. Иймээс нэгтгэгч нь тэрхүү хэсгийг худалдан авалтаас тусдаа тайлагнана.
- (б) Ажил гүйлгээг хэн санаачилсан. Тухайн ажил гүйлгээг хэн санаачилсан гэдгийг мэдэх нь тэрхүү ажил гүйлгээ уг худалдан авсан үйл ажиллагааг авах арилжааны нэг хэсэг мөн эсэх талаар ойлголт өгч болох юм. Тухайлбал; нэгтгэгчийн санаачлан эхлүүлсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн нэгдлээс өмнөх уг худалдан авсан үйл ажиллагаа буюу түүний хуучин эздэд үр ашиггүй буюу маш бага үр ашигтай боловч нэгтгэгч эсвэл тэрхүү нэгдсэн байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж бүрдүүлэх зорилгоор хийгдсэн байж болно. Нөгөө талаас, худалдан авсан үйл ажиллагаа буюу түүний хуучин эздийн санаачлан эхлүүлсэн ажил гүйлгээ буюу хэлцэл нь нэгтгэгч болон уг нэгдсэн байгууллагад үр өгөөжтэй байх магадлал багатай бөгөөд худалдан авалтын ажил гүйлгээний нэг хэсэг болох илүү их магадлалтай юм.
- (в) Ажил гүйлгээний цаг хугацаа. Ажил гүйлгээний цаг хугацаа нь тэрхүү ажил гүйлгээ уг худалдан авсан үйл ажиллагааг авах арилжааны нэг хэсэг мөн эсэх талаар бас ойлголт өгч болох юм. Тухайлбал; худалдан авалтын нөхцлийг хэлэлцэх явцад нэгтгэгч ба худалдан авсан үйл ажиллагааны хооронд хийгдсэн ажил гүйлгээг уг нэгтгэгч болон нэгдсэн байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж бий болгох тухайн худалдан авалтын хүрээнд гүйцэтгэсэн байж болно. Хэрэв тийм бол уг худалдан авалтын өмнөх, худалдан авсан үйл ажиллагаа буюу түүний хуучин эздэд нь тэрхүү нэгдсэн байгууллагын нэг хэсэг болгон хүлээн авах үр

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

өгөөжөөс өөр бусад байдлаар тухайн ажил гүйлгээнээс үр өгөөж хүртэхгүй буюу маш бага үр өгөөж хүртэх магадлалтай байдаг.

Нэгтгэгч ба худалдан авсан үйл ажиллагааны хооронд урьдчилан оршин байсан харилцааг уг худалдан авалтаар үр дүнтэйгээр барагдуулах (110(a) параграфыг үзнэ үү)

МЗУ99. Нэгтгэгч ба худалдан авсан үйл ажиллагаа нь тухайн худалдан авалтыг эхлүүлэхээс өмнө оршин байсан харилцаатай байж болох бөгөөд энэ Стандартад түүнийг 'урьдчилан оршин байсан харилцаа' гэж нэрлэсэн. Нэгтгэгч ба худалдан авсан үйл ажиллагааны хоорондох урьдчилан оршин байсан харилцаа нь заавал биелүүлэх хэлцлийн (жишээлбэл; худалдан авагч ба бэлтгэн нийлүүлэгч, эсвэл лиценз өмчлөгч ба лиценз ашиглагч) эсвэл заавал биелүүлэх хэлцлийн бус (жишээлбэл; шүүхийн нэхэмжлэгч ба хариуцагч) харилцаа байж болно.

МЗУ100. Хэрэв худалдан авалт нь урьдчилан оршин байсан харилцааг барагдуулах үр дүнтэй бол нэгтгэгч нь дараах байдлаар хэмжсэн олз эсвэл гарзыг хүлээн зөвшөөрнө:

- (a) Урьдчилан оршин байсан заавал биелүүлэх хэлцлийн бус харилцаа (зарга гэх мэт)-ны хувьд, бодит үнэ цэнээр;
- (б) Урьдчилан оршин байсан заавал биелүүлэх хэлцлийн харилцааны хувьд, доорх (i) ба (ii)-ийн аль бага дүнгээр:
  - (i) Ижил буюу төсөөтэй зүйлсийн одоогийн зах зээлийн ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулахад, нэгтгэгчийн хувьд уг заавал биелүүлэх хэлцэл тааламжтай эсвэл тааламжгүй байх дүн. (Тааламжгүй заавал биелүүлэх хэлцэл гэдэг нь одоогийн зах зээлийн нөхцөлтэй харьцуулахад ашиггүй байх заавал биелүүлэх хэлцэл юм. Энэ нь заавал биелүүлэх хэлцлийн дагуу хүлээсэн үүргээ барагдуулах зайлсхийх боломжгүй зардал нь уг хэлцлийн дагуу авахаар хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөжөөс хэтэрсэн, алдаатай хэлцэл байх албагүй юм.)
  - (ii) Заавал биелүүлэх хэлцэл тааламжгүй байгаа тухайн оролцогч талд бэлэн боломжтой байгаа уг заавал биелүүлэх хэлцэлд заасан аливаа барагдуулалтын нөхцлийн дүн.

Хэрэв (ii)-ийн дүн нь (i)-ийн дүнгээс бага бол зөрүүг тухайн худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн нэг хэсэг байдлаар тусган оруулна.

Хүлээн зөвшөөрсөн олз буюу гарзын дүн нь холбогдох хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэгч өмнө хүлээн зөвшөөрсөн эсэхээс зарим талаар хамаарч болох бөгөөд иймээс тухайн тайлагнасан олз, гарз нь дээрх шаардлагуудыг мөрдснөөр тооцоолсон дүнгээс өөр байж болно.

МЗУ101. Урьдчилан оршин байсан харилцаа нь дахин олж эзэмшсэн эрх байдлаар нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн заавал биелүүлэх хэлцэл байж болно. Хэрэв заавал биелүүлэх хэлцэл нь ижил буюу төсөөтэй зүйлсийн одоогийн зах зээлийн ажил гүйлгээний үнэтэй харьцуулахад тааламжтай эсвэл тааламжгүй нөхцлүүдийг агуулсан бол нэгтгэгч нь МЗУ100-р параграфын дагуу хэмжсэн, тухайн хэлцлийн үр дүнтэй барагдуулалтын олз, гарзыг худалдан авалтаас тусад нь хүлээн зөвшөөрнө.

Ажилтнууд буюу хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигчдэд олгох болзошгүй төлбөрийн хэлцэл (110(б) параграфыг үзнэ үү)

МЗУ102. Ажилтнууд болон хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигчдэд олгох болзошгүй төлбөр нь тухайн худалдан авалтын болзошгүй төлбөр эсвэл тусдаа ажил гүйлгээ эсэх нь уг хэлцлийн шинж чанараас хамаардаг. Худалдан авалтын гэрээнд болзошгүй төлбөрийн нөхцөл оруулсан шалтгаан, түүнийг хэн санаачилсан, уг хэлцлийг талууд хэзээ байгуулсан гэдгийг олж мэдэх нь тэрхүү хэлцлийн шинж төрлийг үнэлэхэд ач холбогдолтой байж болно.

МЗУ103. Ажилтнууд буюу хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигчдэд олгох төлбөр нь уг худалдан авсан үйл ажиллагааг авах арилжааны нэг хэсэг, эсвэл уг худалдан авалтаас тусдаа ажил гүйлгээ эсэх нь тодорхой бус бол нэгтгэгч нь дараах шинж тэмдгүүдийг харгалзан үзнэ:

- (а) Үргэлжлүүлэн ажиллах. Хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигч нь гол чухал ажилтан байдлаар үргэлжлүүлэн ажиллах нөхцөл нь болзошгүй төлбөрийг илтгэх шинж тэмдэг байж болно. Үргэлжлүүлэн ажиллахтай холбоотой нөхцлүүдийг хөдөлмөрийн гэрээ, худалдан авалтын гэрээ болон бусад баримт бичигт тусгаж болно. Харин ажил эрхлэлтийг дуусгавар болговол төлөлтийг автоматаар цуцлах болзошгүй төлбөр нь нэгдлийн дараах хөдөлмөрийн үйлчилгээний цалин урамшуулал болно. Ажил эрхлэлтийг дуусгавар болгосноор болзошгүй төлбөрт нөлөөлөхгүй байх хэлцэл нь уг болзошгүй төлбөр цалин урамшуулал биш, харин нэмэлт төлбөр гэдгийг илэрхийлнэ.
- (б) Үргэлжлүүлэн ажиллах хугацаа. Үргэлжлүүлэн ажиллахаар шаардсан хугацаа нь болзошгүй төлбөрийн хугацаатай ижил буюу түүнээс урт бол энэ нь тухайн болзошгүй төлбөр мөн чанарын хувьд цалин урамшуулал гэдгийг илэрхийлж болох юм.
- (в) Цалин урамшууллын түвшин. Болзошгүй төлбөрөөс бусад ажилтны цалин урамшуулал нь тухайн нэгдсэн байгууллагын бусад гол чухал ажилтны цалин урамшуулалтай харьцуулахад зохих, ул үндэслэлтэй түвшинд байгаа нь тэрхүү болзошгүй төлбөр цалин урамшуулал биш, харин нэмэлт төлбөр гэдгийг илэрхийлж болох юм.
- (г) Ажилтнуудад олгох өсөн нэмэгдсэн төлбөр. Тухайн нэгдсэн байгууллагын ажилтан болохгүй, хувьцаагаа борлуулж буй

хувьцаа эзэмшигч нь тэрхүү нэгдсэн байгууллагын ажилтан болох, хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигчээс нэгж хувьцаанд ногдох арай бага хэмжээний болзошгүй төлбөр авч байвал уг ажилтан болох, хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигчид олгож байгаа болзошгүй төлбөрийн өсөн нэмэгдсэн дүн нь цалин урамшуулал гэдгийг илэрхийлж болох юм.

- (д) Өмчилсэн хувьцааны тоо. Гол чухал ажилтан болж үлдсэн, уг хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигчийн өмчилсэн хувьцааны харгалзах тоо нь болзошгүй төлбөрийн мөн чанарын илэрхийлэл байж болно. Тухайлбал; худалдан авсан үйл ажиллагааны бараг бүх хувьцааг өмчилдөг, хувьцаагаа борлуулж буй тухайн хувьцаа эзэмшигч нь гол чухал ажилтан байдлаар үргэлжлүүлэн ажиллах бол уг хэлцэл нь мөн чанарын хувьд нэгдлийн дараах хөдөлмөрийн үйлчилгээний хариуд цалин урамшуулал олгох зорилго бүхий, ашиг хуваах хэлцэл гэдгийг илэрхийлж болох юм. Нөгөө талаас, гол чухал ажилтан байдлаар үргэлжлүүлэн ажиллах, уг хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигчид нь тухайн худалдан авсан үйл ажиллагааны зөвхөн цөөн тооны хувьцааг өмчлөх бөгөөд хувьцаагаа борлуулж буй бүх хувьцаа эзэмшигчид нь нэгж хувьцаанд ногдох ижил дүнгээр болзошгүй төлбөрийг хүлээн авдаг бол тэрхүү болзошгүй төлбөр нь нэмэлт төлбөр гэдгийг илэрхийлж болох юм. Гол чухал ажилтан байдлаар үргэлжлүүлэн ажиллах, уг хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигчдийн гэр бүлийн гишүүд гэх мэт холбоотой талуудын эзэмшиж байсан, тэрхүү худалдан авалтын өмнөх өмчлөлийн хувь оролцоог мөн харгалзан үзэх хэрэгтэй.
- (е) Үнэлгээтэй холбоотой байдал. Худалдан авалтын өдрөөр шилжүүлсэн анхны төлбөр нь худалдан авсан үйл ажиллагааны талаархи үнэлгээгээр тогтоосон хамгийн бага хэмжээнд үндэслэдэг бөгөөд болзошгүй төлбөрийн томъёолол нь уг үнэлгээний арга хандлагатай холбоотой бол болзошгүй төлбөр нь нэмэлт төлбөр гэдгийг илэрхийлж болох юм. Нөгөө талаас, хэрэв болзошгүй төлбөрийн томъёолол нь ашиг хуваах талаархи өмнөх хэлцэлтэй нийцдэг бол уг хэлцэл нь цалин урамшуулал олгох шинж чанартай гэдгийг илэрхийлж болох юм.
- (ж) Төлбөрийг тодорхойлох томъёолол. Болзошгүй төлбөрийг тодорхойлоход ашигласан томъёолол нь уг хэлцлийн мөн чанарыг үнэлэхэд ач холбогдолтой байж болно. Тухайлбал; болзошгүй төлбөрийг олон ашигт үндэслэн тодорхойлдог бол тухайн үүрэг нь худалдан авалтын болзошгүй төлбөр гэдгийг, харин томъёолол нь уг худалдан авсан үйл ажиллагааны бодит үнэ цэнийг тогтоох буюу шалгах зорилготой гэдгийг илэрхийлж болох юм. Харин эсрэгээр, ашгийн тохиролцсон хувиар тооцогдох болзошгүй төлбөр нь ажилтнуудын үзүүлсэн үйлчилгээний хариуд тэднийг урамшуулах, ашиг хуваах хэлцэл гэдгийг илэрхийлж болох юм.



- (и) Бусад гэрээ ба асуудлууд. Хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигчидтэй хийсэн бусад хэлцлийн нөхцлүүд (үл өрсөлдөх гэрээ, гүйцэтгэлийн гэрээ, зөвлөх үйлчилгээний гэрээ, үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ гэх мэт) ба болзошгүй төлбөрийн татварын арга хандлага нь худалдан авсан үйл ажиллагаанд олгох төлбөрөөс өөр бусад ямар нэг зүйлд тухайн болзошгүй төлбөр хамааралтай гэдгийг илэрхийлж болох юм. Жишээлбэл; худалдан авалттай холбоотойгоор нэгтгэгч нь том хэмжээний хувьцаагаа борлуулж буй хувьцаа эзэмшигчтэй үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан байж болно. Хэрэв түрээсийн гэрээнд заасан түрээсийн төлбөр нь зах зээлийн түвшнээс мэдэгдэхүйц бага бол болзошгүй төлбөрийн талаархи тусдаа хэлцлээр түрээслүүлэгчид (хувьцаагаа борлуулж буй уг хувьцаа эзэмшигчид) төлөхийг шаардсан, бүх буюу зарим болзошгүй төлбөр нь мөн чанарын хувьд, нэгтгэгч тухайн нэгдлийн дараах өөрийн санхүүгийн тайландаа тусад нь хүлээн зөвшөөрвөл зохих уг түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын төлбөр байж болох юм. Харин эсрэгээр, түрээсийн гэрээнд заасан түрээсийн төлбөр нь тэрхүү түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн түвшинтэй нийцдэг бол хувьцаагаа борлуулж буй тухайн хувьцаа эзэмшигчид олгох болзошгүй төлбөр нь уг худалдан авалтын болзошгүй төлбөр байж болно.

Худалдан авсан үйл ажиллагааны ажилтнуудын эзэмшиж байсан урамшууллаар солилцсон, нэгтгэгчийн хувьцаанд суурилсан төлбөрийн урамшуулал (110(б) параграфыг үзнэ үү)

МЗУ104. Нэгтгэгч нь тухайн худалдан авсан үйл ажиллагааны ажилтнуудын эзэмшиж байсан урамшууллаар өөрийн хувьцаанд суурилсан төлбөрийн урамшууллыг солилцож болох юм. Худалдан авалттай холбоотой хувьцааны опцион буюу хувьцаанд суурилсан бусад төлбөрийн урамшууллын солилцоог уг нэгтгэгч нь хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу тайлагнана.

МЗУ105. Худалдан авсан үйл ажиллагааны урамшууллын хугацаа нь уг худалдан авалтын улмаас дууссан ба нэгтгэгч нь үүрэг хүлээгээгүй боловч тэдгээр урамшууллыг сольж орлуулан өгөх тохиолдолд тухайн нэгтгэгч нь аливаа зардлыг тэрхүү нэгдлийн дараах өөрийн санхүүгийн тайландаа хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу цалин урамшууллын зардал гэж хүлээн зөвшөөрнө. Эдгээр урамшууллын өртөг зардлыг тухайн худалдан авалтаар шилжүүлсэн төлбөрийг хэмжихэд харгалзан тусгахгүй.

Худалдан авсан үйл ажиллагааны өмчөөр барагдуулах, хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээ

МЗУ106. Худалдан авсан үйл ажиллагаа нь төлөгдөөгүй, өөрөөр хэлбэл нэгтгэгч өөрийн хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээгээр солилцоогүй,

тийм хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээтэй байж болно. Хэрэв баталгаажуулвал, уг худалдан авсан үйл ажиллагааны тэдгээр хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээнүүд нь тухайн худалдан авсан үйл ажиллагаан дахь хяналтын бус хувь оролцооны нэг хэсэг болно. Хэрэв баталгаажуулаагүй бол тухайн худалдан авалтын өдөр нь олгох өдөр байсан мэтээр тэдгээрийг хэмжинэ. Хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу тэрхүү хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээг хэмжинэ.

*Дараагийн тайлант үеийн хэмжилт ба тайлагнал (112-р параграфыг үзнэ үү)*

МЗУ107. Худалдан авалтаар олж эзэмшсэн хөрөнгө ба хариуцсан буюу хүлээсэн өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт болон тайлагналын талаархи заавар удирдамжаар хангадаг бусад УСНББОУС-уудын жишээ нь:

- (а) УСНББОУС 31 нь худалдан авалтаар олж эзэмшсэн тодорхойлогдох биет бус хөрөнгийн тайлагналыг тодорхойлдог. Нэгтгэгч нь уг худалдан авалтын өдрөөр хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр гүүдвилийг хэмждэг. УСНББОУС 26 нь үнэ цэнийн бууралтын гарзын тайлагналыг тодорхойлдог.
- (б) УСНББОУС 35 нь хяналтыг олж авсны дараа хяналтанд буй байгууллага дахь хяналт тавигч байгууллагын өмчлөлийн хувь оролцоонд гарсан өөрчлөлтийн тайлагналын талаархи заавар удирдамжаар хангадаг.

МЗУ108. Даатгалын гэрээ, орлогын албан татвар, хувьцаанд суурилсан төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт болон тайлагналын хувьд нэгтгэгч нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартыг лавлагаа болгох хэрэгтэй.

*Худалдан авалтын үр дүнд өөрчлөгдөж болох шалгуурт үндэслэн нэгтгэгч буюу тухайн худалдан авсан үйл ажиллагааны хүлээн авсан шилжүүлэг, хөнгөлөлттэй зээл ба адилтгах өгөөжийн дараагийн тайлант үеийн хэмжилт (114-р параграфыг үзнэ үү)*

МЗУ109. Худалдан авалтыг хийхээс өмнө нэгтгэгч эсвэл худалдан авсан үйл ажиллагаа нь тодорхой шалгуурт үндэслэн гуравдагч талаас шилжүүлэг хүлээн авч болно. Жишээлбэл; тухайн нутгийн нэг хүнд ногдох орлого нь босго шалгуураас доогуур байх тэдгээр нутгийн захиргаадад үндэсний засгийн газраас буцалтгүй тусламж олгодог байж болох юм. Мөнгө бий болгогч үйл ажиллагааг тухайн нутгийн захиргаа худалдан авах нь уг нутгийн нэг хүнд ногдох орлогыг нэмэгдүүлж, ингэснээр босго шалгуураас өндөр болгож болох юм. Энэ нь засгийн газар өөрийн олгох буцалтгүй тусламжийг дахин хянан үнэлэхэд хүргэж болно.

МЗУ110. Нэгтгэгч нь буцалтгүй тусламжийн дүнд оруулсан аливаа засвар өөрчлөлтийг уг худалдан авалтын нэг хэсэг байдлаар тайлагнадаггүй боловч санхүүжүүлэгч нь өөрийн санаа зорилгыг мэдэгдсэн тэр агшинд тус нэгтгэгч нь аливаа засвар өөрчлөлтийг бусад УСНББОУС-уудын дагуу тайлагнана.

МЗУ111. Хөнгөлөлттэй зээл болон бусад өгөөжийн хувьд үүнтэй адилтгах нөхцөл байдал үүсэж болох юм. Нэгтгэгч нь эдгээр ажил гүйлгээний аливаа засвар өөрчлөлтийг уг худалдан авалтын нэг хэсэг байдлаар тайлагнадаггүй боловч санхүүжүүлэгч нь өөрийн санаа зорилгыг мэдэгдсэн тэр агшинд тус нэгтгэгч нь аливаа засвар өөрчлөлтийг бусад УСНББОУС-уудын дагуу тайлагнана.

*Тайлант үеийн туршид хийсэн худалдан авалтууд*

МЗУ112. Худалдан авалтын өмнөх уг худалдан авсан үйл ажиллагааны талаархи мэдээллийн хувьд өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг тухайн үр дүнгийн байгууллага нь 120(у) параграфт заасан, тодруулгыг хийх замаар хангана.

МЗУ113. Зохицуулагч байгууллагын шаардлагыг биелүүлэхийн тулд нэгтгэгч нь энэ Стандартаар шаардснаас гадна бусад мэдээллийг толилуулах буюу тодруулах шаардлагатай байж болно.

**Зөвхөн хамтын байгууллагуудыг хамарсан эсвэл зөвхөн гэрээгээр хийгдсэн улсын секторын нэгдлийн шилжилтийн нөхцлүүд (133-р параграфыг үзнэ үү)**

МЗУ114. 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх анхны тайлант жилийн эхэнд эсвэл түүнээс хойшхи худалдан авалтын өдөр буюу нийлүүлэх өдөр бүхий улсын секторын нэгдлийн хувьд энэхүү Стандартыг гүйцээх горимоор мөрдөнө гэж 126-р параграфт заасан. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

МЗУ115. Улсын секторын нэгдлийн худалдан авалтын өдөр эсвэл нийлүүлэх өдөр нь энэ Стандартыг мөрдөхөөс өмнө байвал энэ Стандартыг мөрдөх шаардлага нь зөвхөн хамтын байгууллагуудыг хамарсан эсвэл зөвхөн гэрээгээр хийгдэх улсын секторын нэгдлийн хувьд дараах үр нөлөөтэй байна:

(а) Ангилал. Байгууллага нь өмнөх улсын секторын нэгдлийг ийм нэгдэлд зориулсан өөрийн өмнөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилсан хэвээр байх.

(б) Өмнө хүлээн зөвшөөрсөн гүүдвил. Энэ Стандартыг мөрдсөн анхны тайлант жилийн эхэн дэх, уг өмнөх улсын секторын нэгдлээс үүссэн гүүдвиллийн дансны үнэ нь уг байгууллагын өмнөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу тайлагнасан тухайн өдрөөрх түүний дансны үнэ байна. Энэхүү дүнг тодорхойлохдоо, байгууллага нь гүүдвиллийн аливаа хуримтлагдсан хорогдуулгын дүн болон уг

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

гүүдвилийн харгалзах бууралтыг хасна. Гүүдвилийн дансны үнэд өөр бусад залруулга хийхгүй.

- (в) Өмчөөс хасагдах дүн байдлаар өмнө нь хүлээн зөвшөөрсөн гүүдвил. Байгууллагын өмнөх нягтлан бодох бүртгэлийн бодлого нь өмнөх улсын секторын нэгдлээс үүссэн гүүдвилийг өмчөөс хасагдах дүн байдлаар хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн байж болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь энэ Стандартыг мөрдсөн анхны тайлант жилийн эхэнд уг гүүдвилийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй. Түүнчлэн, байгууллага нь уг гүүдвилтэй холбоотой үйл ажиллагаагаа бүгдийг буюу түүний зарим хэсгийг данснаас хассан, эсвэл уг гүүдвилийн хамаарах мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ буурсан тохиолдолд тэрхүү гүүдвилийн аливаа хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхгүй.
- (г) Гүүдвилийн дараагийн тайлант үеийн тайлагнал. Энэ Стандартыг мөрдсөн анхны тайлант жилийн эхнээс байгууллага нь уг өмнөх улсын секторын нэгдлээс үүссэн гүүдвилийн хорогдуулгыг зогсоох ба гүүдвилийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 26-гийн дагуу сорьж шалгана.
- (д) Өмнө нь хүлээн зөвшөөрсөн сөрөг гүүдвил. Өмнөх улсын секторын нэгдлээ худалдан авалтын аргаар тайлагнадаг байгууллага нь худалдан авсан үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцооны өртгөөс давсан, уг худалдан авсан үйл ажиллагааны тодорхойлогдох хөрөнгө ба өр төлбөрийн цэвэр бодит үнэ цэнэ дэх өөрийн хувь оролцооны тэрхүү илүүдэл дүнг (зарим үед сөрөг гүүдвил гэж нэрлэдэг) хойшлогдсон кредит байдлаар хүлээн зөвшөөрч болох юм. Ингэж хүлээн зөвшөөрдөг бол байгууллага нь энэ Стандартыг мөрдсөн анхны тайлант жилийн эхэн дэх уг хойшлогдсон кредитийн дансны үнийг тэрхүү өдрөөрх хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийн харгалзах залруулгын хамтаар үл хүлээн зөвшөөрнө.

## Хавсралт Б

### Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт

#### УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Толилуулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт

135-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 153М параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

#### Тодруулга

...

#### Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга

...

135. Байгууллага бүр нь өөрийн үйл ажиллагааны шинж төрөл болон тухайн төрлийн байгууллагын хувьд тодруулна гэж түүний санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн хүлээж болох бодлогуудыг харгалзан үздэг. Жишээлбэл; татвар, хандив болон бусад төрлийн арилжааны бус орлогын хүлээн зөвшөөрөлтийн талаархи нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулна гэж улсын секторын байгууллагуудаас хүлээдэг. Байгууллага нь мэдэгдэхүйц хэмжээний гадаад үйл ажиллагаатай буюу гадаад валютаар хийгдэх мэдэгдэхүйц их ажил гүйлгээтэй тохиолдолд гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзын хүлээн зөвшөөрөлтийн талаархи нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг хийнэ гэж хүлээдэг. ~~Байгууллагын нэгдэл~~ Улсын секторын нэгдэл хийсэн тохиолдолд гүүдвил болон хяналтын бус хувь оролцоог хэмжихдээ ашигласан бодлогуудыг тодруулна.

...

#### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 153М. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 135-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## **УСНББОУС 10, Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

22-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 38Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### **Санхүүгийн тайлангийн дахин илэрхийлэлт**

...

### **Санхүүгийн байдлын тайлан**

...

22. Мөнгөн бус зүйлийн дахин илэрхийлсэн дүнгийн үнэ цэнэ буурсан ба түүнийг бууруулах хэрэгтэй эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт эсвэл* УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-д болон гүүдвиллийн үнэ цэнийн бууралтыг авч үздэг нягтлан бодох бүртгэлийн олон улсын ба/буюу үндэсний стандартад заасан холбогдох үнэ цэнийн бууралтын сорилыг мөрдөнө. Жишээлбэл; үндсэн хөрөнгө, гүүдвил, патент, худалдааны тэмдгийн дахин илэрхийлсэн дүнг тэдгээрийн нөхөгдөх дүн буюу нөхөгдөх үйлчилгээний дүн, бараа материалын дахин илэрхийлсэн дүнг тэдгээрийн цэвэр боломжит үнэ цэнэ буюу одоогийн орлуулалтын өртгийн аль тохиромжтой хүртэл бууруулна. Өмчийн аргаар тайлагнагдсан санхүүжигч нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлангаа бэлтгэдэг байж болох юм. Ийм санхүүжигчийн цэвэр хөрөнгө/өмч болон ашиг, алдагдалд тухайн хөрөнгө оруулагчийн эзлэх хувь оролцоог тооцохын тулд уг санхүүжигчийн санхүүгийн байдлын тайлан болон санхүүгийн үр дүнгийн тайланг энэхүү Стандартын дагуу дахин илэрхийлнэ. Тухайн санхүүжигчийн дахин илэрхийлсэн санхүүгийн тайланг гадаад валютаар толилуулдаг тохиолдолд түүнийг хаалтын ханшаар хөрвүүлнэ.

...

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

...

- 38Д. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 22-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ

тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## **УСНББОУС 14, Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

31-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 32Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### Тодруулга

...

### **Тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын тодруулга**

...

31. Тодруулга хийхэд ерөнхийдөө хүргэдэг тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын жишээг доор дурдав:

- (а) Бодит үнэ цэнээр бүртгэсэн үл хөдлөх хөрөнгийн тухайн тайлангийн өдрөөрх нөхцөл байдалтай холбоогүй боловч уг тайлангийн өдрөөс хойш үүссэн нөхцөл байдлынулмаас түүний үнэ цэнэд гарсан хэвийн бус том хэмжээний бууралт;
- (б) Байгууллага нь өөрийн эрхлэн ажиллуулдаг нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүдийн оролцогчдод шууд буюу шууд бус байдлаар ирээдүйд нэмэлт тэтгэмж олгохоор/хуваарилахаар тайлангийн өдрийн дараа шийдвэрлэсэн бөгөөд тэдгээр нэмэлт тэтгэмж нь тухайн байгууллагад томоохон нөлөө үзүүлэхээр байх;
- (в) Тайлангийн өдрийн дараах улсын секторын томоохон нэгдэл (УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл нь ийм тохиолдолд тусгай тодруулга хийхийг шаарддаг), хяналтанд буй томоохон байгууллагын худалдан авалт буюу данснаас хасалт, байгууллагын одоо эрхлэн явуулж буй бүх буюу бараг бүх үйл ажиллагааг аутсорсингоор гүйцэтгүүлэх;

...

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

...

32Д. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 31-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн

санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## **УСНББОУС 16, Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

87, 90-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан ба 18А, 101Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### **Тодорхойлолт**

...

### **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**

...

18А Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт нь нэг хөрөнгийн буюу хөрөнгүүдийн бүлгийн худалдан авалт эсвэл УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн цар хүрээнд хамаарах улсын секторын нэгдэл эсэхийг тодорхойлохын тулд мөн шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Улсын секторын нэгдэл мөн эсэхийг тодорхойлохын тулд УСНББОУС 40-ийг лавлагаа болговол зохино. Уг үл хөдлөх хөрөнгө нь эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө эсвэл хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт нь УСНББОУС 40-д тодорхойлсон улсын секторын нэгдэл мөн эсэхээс үл хамааран энэ Стандартын 9-18-р параграф дахь хэлэлцүүлгийг харгалзан үзнэ. Тухайн ажил гүйлгээ УСНББОУС 40-д заасан улсын секторын нэгдлийн тодорхойлолтыг хангах ба энэ Стандартад заасанчлан, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд хамаарах эсэхийг тодорхойлох нь энэхүү хоёр Стандартын аль алины тусдаа мөрдөлт, хэрэглээг шаардах юм.

...



## Тодруулга

### Бодит үнэ цэнийн загвар ба өртгийн загвар

...

#### *Бодит үнэ цэнийн загвар*

87. 42-64-р параграфт заасан бодит үнэ цэнийн загварыг ашигладаг байгууллага нь 86-р параграфтаар шаардсан тодруулгаас гадна хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнэ хоорондох тохируулгын тайланг бэлтгэж толилуулах бөгөөд үүнд дараах зүйлсийг харуулна:
- (a) Нэмэгдэлт, үүнд: худалдан авалтын үр дүнд нэмэгдсэн хөрнгө ба тухайн хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрсөн дараагийн тайлант үеийн зарлагын үр дүнд нэмэгдсэн хөрөнгийг тусдаа тодруулах;
  - (б) ~~Байгууллагын нэгдлээр~~ Улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн нэмэгдэлт;

...

#### *Өртгийн загвар*

90. 65-р параграфт дурдсан өртгийн загварыг ашигладаг байгууллага нь 86-р параграфтаар шаардсан тодруулгаас гадна дараах зүйлсийг тодруулна:
- (a) Ашигласан элэгдэл тооцох арга;
- ...
- (г) Доорх зүйлсийг харуулсан, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнийн тохируулга:
    - (i) Нэмэгдэлт, үүнд: худалдан авалтын үр дүнд нэмэгдсэн хөрнгө ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн дараагийн тайлант үеийн зарлагын үр дүнд нэмэгдсэн хөрөнгийг тусдаа тодруулах;
    - (ii) ~~Байгууллагын нэгдлээр~~ Улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн, нэмэгдсэн хөрөнгө;
    - (iii) Данснаас хасалт;

...

## Хүчин төгөлдөр болох хугацаа

...

101Д. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 18А параграфыг шинээр нэмж, 87 ба 90-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр

нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд мөн тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## **УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

60, 88-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан ба 107П параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### **Элэгдэл**

...

60. Байгууллага нь тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн хувьд анх хүлээн зөвшөөрсөн дүнг түүний мэдэгдэхүйц хэсгүүдэд хуваарилах ба тэрхүү хэсэг тус бүрийг тусад нь элэгдүүлнэ. Жишээлбэл; авто замын системийн доторх замын хажуугийн явган зам, замын хучилт, замын хашлага, суваг, явган зам, гүүр, гэрлэн дохиог тусад нь элэгдүүлэхийг шаарддаг. Үүнтэй адилаар, онгоцыг өөрөө өмчилдөг эсвэл санхүүгийн түрээсээр түрээслэдэг эсэхээс үл хамаран нисэх онгоцны их бие ба түүний хөдөлгүүрийг тусад нь элэгдүүлэх нь тохиромжтой байж болох юм. Хэрэв байгууллага нь өөрөө түрээслүүлэгч байх тийм үйл ажиллагааны түрээсээр үндсэн хөрөнгийг түрээслэх үүднээс худалдан авсан бол зах зээлийн нөхцөлтэй харьцуулахад тааламжтай эсвэл тааламжгүй түрээсийн нөхцөлд хамаарах үндсэн хөрөнгийн зүйлсийн өртгийг тус тусад нь элэгдүүлэх нь тохиромжтой байж болно.

88. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн үндсэн хөрөнгийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг санхүүгийн тайланд тодруулна:

(а) Нийт дансны үнийг тодорхойлоход ашигласан хэмжилтийн сууриуд;

...

(д) Доорх зүйлсийг харуулсан, тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнийн тохируулга:

(i) Нэмэгдэлт;

(ii) Данснаас хасалт;

(iii) Байгууллагын нэгдлээрх Улсын секторын нэгдлээрх худалдан авалт;

...

## Хүчин төгөлдөр болох хугацаа

...

107П. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 60, 88-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## УСНББОУС 18, Сегментийн Тайлагнал-д оруулсан нэмэлт өөрчлөлт

34, 37-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан ба 76Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

## Сегментийн орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодорхойлолт

...

### Сегментийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал

...

34. Засгийн газрын болон бусад байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь байгууллагын нэгдлээр улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн ба худалдан авалтын гүүдвил үүсгэдэг үйл ажиллагаануудыг байгууллагуудыг өөртөө агуулдаг байж болох юм (байгууллагын үйл ажиллагааны худалдан авалтыг тайлагнах талаархи заавар удирдамжийг СТОУС 3, Бизнесийн Нэгдэл УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-д тусгасан). Ийм тохиолдолд сегментэд шууд хамаарах буюу үндэслэлтэй сууриар түүнд хуваарилж болох гүүдвил нь сегментийн хөрөнгөнд, харин гүүдвیلیйн холбогдох хөрөгдуулга үнэ цэнийн бууралт нь сегментийн зардалд хамаарна.

...

37. Улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн байгууллагын үйл ажиллагааны тухайн тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд тохируулга хийхийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний

стандартаар УСНББОУС 40-өөр шаардаж болох юм (тухайлбал, СТОУС 3-ыг үзнэ үү). Худалдан авалт байдлаар тайлагнасан байгууллагын нэгдлээр Худалдан авалтаар олж эзэмшсэн үйл ажиллагааны байгууллагын тухайн тодорхойлогдох сегментийн хөрөнгө, өр төлбөрийн өмнөх дансны үнийн аливаа тохируулгыг зөвхөн нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор хийдэг бөгөөд хяналт тавигч байгууллагын тусдаа эсвэл хяналтанд буй байгууллагын бие даасан санхүүгийн тайлангийн аль нэгэнд түүнийг бүртгэдэггүй боловч тэдгээр залруулгыг тухайн сегментийн хөрөнгө, өр төлбөрийн хэмжилтэнд тусган оруулна. Үүнтэй адилаар, үндсэн хөрөнгийг түүний худалдан авалтын дараа УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-д заасан дахин үнэлгээний загварын дагуу дахин үнэлсэн бол тэрхүү дахин үнэлгээг сегментийн хөрөнгийн хэмжилтэнд тусгана.

...

## Хүчин төгөлдөр болох хугацаа

...

76Д. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 34, 37-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## **УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

4А ба 111Ж параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

## Цар хүрээ

...

4А. УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн цар хүрээнд хамаарах улсын секторын нэгдэл дэх нэгтгэгчийн болзошгүй төлбөрт энэ Стандартыг мөрдөхгүй.

...

## Хүчин төгөлдөр болох хугацаа

...

111Ж. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 4А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-д оруулсан нэмэлт өөрчлөлт

14-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан ба 20А, 82И параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### Тодорхойлолт

14. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

...

Мөнгө бий болгогч хөрөнгө гэдэг нь худалдаа арилжааны өгөөж бий болгох үндсэн зорилготойгоор эзэмшиж буй хөрөнгө юм. Үнэ цэнийн бууралтын зорилгын хувьд гүүдвилийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзнэ.

...

### Мөнгө бий болгогч хөрөнгө

...

20А. Үнэ цэнийн бууралтын зорилгын хувьд гүүдвилийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үздэг. Гүүдвил нь бусад хөрөнгүүдээс бие даасан байдлаар эдийн засгийн үр өгөөжийг бий болгодоггүй бөгөөд түүний үнэ цэнийн бууралтыг бусад хөрөнгүүдийн бүлгийн нэг хэсэг байдлаар үнэлдэг. Бие даасан хөрөнгүүдийн үнэлгээг энэ Стандартад авч үзнэ. Гүүдвил нь

зөвхөн мөнгөн орлогын гүйлгээ үүсгэх эсвэл нэгтгэгчийн цэвэр мөнгөн зарлагыг бууруулах үр дүнтэй тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрнө. Холбогдох мөнгөн гүйлгээг бий болгохгүй үйлчилгээний чадавхийн хувьд гүүдвилийг хүлээн зөвшөөрөхгүй. Үнэ цэнийн бууралтыг үнэлэхийн тулд энэ Стандартад ашигласан нөхөгдөх үйлчилгээний дүнд үйлчилгээний чадавхи хамаарна. Иймээс байгууллага нь гүүдвилийн үнэ цэнийг бууруулах эсэхийг тодорхойлохын тулд энэ Стандартыг биш, харин УСНББОУС 26-г мөрдөнө.

...

## **Хүчин төгөлдөр болох хугацаа**

...

82И. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 14-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 20А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## **Дүгнэлтийн үндэслэл**

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 21-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

## **Мөнгө бий болгогч хөрөнгө**

...

ДҮ5А. УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийг 2017 оны 01 дүгээр сард гаргасан. УСНББОУС 40 нь гүүдвилийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг агуулсан байдаг. УСНББОУС 40-ийг боловсруулахдаа, УСНББОУС3 нь гүүдвилийн үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг харгалзан үзсэн. Гүүдвил нь бусад хөрөнгүүдээс бие даасан байдлаар эдийн засгийн үр өгөөж бий болгодоггүй, иймээс хөрөнгүүдийн бүлгийн нэг хэсэг байдлаар түүний үнэ цэнийн бууралтыг үнэлнэ гэдгийг УСНББОУС3 онцлон тэмдэглэдэг. Эерэг мөнгөн орлогын гүйлгээ эсвэл цэвэр мөнгөн зарлагын гүйлгээний бууралт эсэхээс үл хамааран мөнгөн гүйлгээг зөвхөн лавлагаа болгосноор гүүдвилийг хэмжиж болно. УСНББОУС 21 нь зөвхөн бие даасан хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг авч үздэг бөгөөд тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийг харгалзсанаар үнэ цэнийн бууралтыг үнэлдэг гэдгийг

УСНББОУСЗ мөн тэмдэглэсэн байдаг. Иймээс УСНББОУСЗ нь гүүдвилийн үнэ цэнийн бууралтанд УСНББОУС 21-ийг мөрдөх нь тохиромжгүй гэж дүгнэсэн. Гүүдвилийн хамаарах үйл ажиллагаа нь мөнгө бий болгогч үйл ажиллагаа эсэхээс үл хамааран үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвилийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзвэл зохино гэж УСНББОУСЗ дүгнэсэн. УСНББОУСЗ нь үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвилийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзэх нэмэлт заавар удирдамжийг УСНББОУС 21 ба УСНББОУС 26-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

## **УСНББОУС 23, Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

1, 2, 6-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан ба 124Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### **Зорилго**

1. Энэ Стандартын зорилго нь улсын секторын нэгдэлд байгууллагын нэгдэлд хүргэдэг арилжааны бус ажил гүйлгээнээс бусад, арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын санхүүгийн тайлагналын шаардлагуудыг тодорхойлоход оршино. Энэ Стандарт нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогыг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ харгалзан үзэх шаардлагатай асуудлууд, үүн дотроо эздийн хувь оролцооны тодорхойлолтыг авч үзнэ.

### **Цар хүрээ**

2. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогыг тайлагнахдаа энэхүү Стандартыг мөрдөнө. Арилжааны бус ажил гүйлгээ болох улсын секторын нэгдэлд байгууллагын нэгдэлд энэ Стандартыг мөрдөхгүй.

...

6. Засгийн газар нь улсын секторын зарим байгууллагуудыг хооронд нь нэгтгэх, ба зарим байгууллагуудыг хоёр буюу хэд хэдэн тусдаа байгууллагуудад хуваах замаар улсын секторт дахин зохион байгуулалт хийж болно. Тайлагнагч нэг байгууллага үүсгэн бий болгохын тулд хоёр буюу хэд хэдэн үйл ажиллагааг тайлагнагч байгууллагыг нэгтгэн нийлүүлэх үед улсын секторын нэгдэл байгууллагын нэгдэл үүсдэг. Ийм бүтцийн өөрчлөлт нь нэг байгууллага өөр нэг үйл ажиллагаа эсвэл байгууллагыг худалдан авахтай ихэвчлэн холбоогүй байдаг боловч шинэ эсвэл одоо оршин буй байгууллага нь өөр нэг үйл ажиллагааны эсвэл байгууллагын бүх хөрөнгө, өр төлбөрийг олж эзэмшихэд бүтцийн өөрчлөлт хийгдэж болох юм. УСНББОУСЗ нь байгууллагын нэгдлийг авч

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

үзээгүй бөгөөд түүнийг энэ Стандартын цар хүрээнд оруулаагүй. Иймээс арилжааны бус ажил гүйлгээ болох байгууллагын нэгдэл нь орлого бий болгох эсвэл үгүй эсэхийг энэ Стандартад тусгайлан заагаагүй. Улсын секторын нэгдлийг УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн дагуу тайлагнана.

...

### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

124Д. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 1, 2, 6-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

### Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 23-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

### Улсын секторын Байгууллагын нэгдэл

...

ДҮ8. Анх гаргах үед энэ Стандарт нь арилжааны бус ажил гүйлгээний үр дүн болох байгууллагын нэгдэл нь орлого үүсэхэд хүргэх эсэхийг тусгайлан заадаггүй байсан. Яагаад гэвэл, УСНББОУС3 нь улсын сектор дахь байгууллагын нэгдлийн санхүүгийн тайлагналыг, үүн дотроо улсын секторын байгууллагуудад СТОУС 3, *Бизнесийн Нэгдэл-ийн* мөрдөгдөх боломжит байдлыг харгалзан авч үзээгүй байсан.

ДҮ8А. Харин дараа нь УСНББОУС3 нь УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийг гаргасан. УСНББОУС 40 нь улсын секторын нэгдлийн тайлагнал, үүн дотроо аливаа олз буюу гарзын тайлагналыг тусгайлан заасан байдаг. Иймээс улсын секторын нэгдлийг энэ Стандартын цар хүрээнд хамруулдаггүй.



## **УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

2, 23, 71, 76, 88, 91, 92, 98-100, 102, 103, 106-108, 110, 111, 120, 122, 123-125-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан ба 71, 76-р параграфын өмнөх гарчгийг өөрчилсөн. 18А, 20А, 90А-90Р, 97А-97И, 111А, 111Б, 122А, 126Л параграфууд, түүнчлэн 90, 97, 111-р параграфын дараах гарчгийг шинээр нэмсэн. 7, 96-р параграфыг хассан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### **Цар хүрээ**

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь доор дурдсанаас бусад, мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тайлагнахдаа энэ Стандартыг мөрдөнө:**

...

(к) ~~Гүүдвил;~~

...

7. ~~Энэхүү Стандартын цар хүрээнд гүүдвилийг тусган оруулаагүй. Байгууллагууд нь гүүдвилийн үнэ цэнийн бууралт, мөнгө бий болгогч нэгжүүдэд гүүдвилийг хуваарилалт, гүүдвил бүхий мөнгө бий болгогч нэгжүүдийн үнэ цэнийн бууралтын сорил зэргийг авч үздэг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын шаардлагуудыг мөрдөнө.~~

...

### **Тодорхойлолт**

...

### **Мөнгө бий болгогч хөрөнгө**

...

- 18А. Үнэ цэнийн бууралтын зорилгын хувьд гүүдвилийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үздэг. Гүүдвил нь бусад хөрөнгүүдээс бие даасан байдлаар эдийн засгийн үр өгөөжийг бий болгодоггүй бөгөөд түүний үнэ цэнийн бууралтыг бусад хөрөнгүүдийн бүлгийн нэг хэсэг байдлаар үнэлдэг. Бие даасан хөрөнгүүдийн үнэлгээг УСНББОУС 21-д авч үзнэ. Гүүдвил нь мөнгөн орлогын гүйлгээ үүсэх эсвэл нэгтгэгчийн цэвэр мөнгөн зарлагыг бууруулах үр дүнтэй байх зөвхөн тийм тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрнө. Холбогдох мөнгөн гүйлгээг бий болгохгүй үйлчилгээний чадавхийн хувьд гүүдвилийг хүлээн зөвшөөрөхгүй. Үнэ цэнийн бууралтыг

үнэлэхийн тулд УСНББОУС 21-д ашигласан нөхөгдөх үйлчилгээний дүнд үйлчилгээний чадавхи хамаарна. Иймээс байгууллага нь гүүдвилийн үнэ цэнийг бууруулах эсэхийг тодорхойлохын тулд энэ Стандартыг мөрдөнө.

## **Үнэ цэнэ буурсан байж болох хөрөнгийг тодорхойлох**

20А. Нөхөгдөх үйлчилгээний дүнг хэзээ тодорхойлохыг 21-30-р параграфт тусгайлан заасан. Эдгээр шаардлагуудад “хөрөнгө” гэсэн нэр томъёог ашигласан боловч энэ нэр томъёог бие даасан хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжид ижил утгаар хэрэглэнэ. Энэхүү Стандартын үлдсэн зүйл заалтуудыг дараах байдлаар бүтэцлэн зохион байгуулсан:

- (а) Нөхөгдөх дүнг хэмжих шаардлагуудыг 31-70-р параграфт заасан. Эдгээр шаардлагуудад мөн “хөрөнгө” гэсэн нэр томъёог ашигласан боловч энэ нэр томъёог бие даасан хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжид ижил утгаар хэрэглэнэ.
- (б) Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг 71-97-р параграфт заасан. Гүүдвилээс бусад бие даасан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг 71-75-р параграфт авч үзсэн. Мөнгө бий болгогч нэгж ба гүүдвилийн үнэ цэнийн бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг 76-97-р параграфт заасан.
- (в) Хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах шаардлагуудыг 98-105-р параграфт заасан. Дахин дурдахад, эдгээр шаардлагуудад “хөрөнгө” гэсэн нэр томъёог ашигласан боловч энэ нэр томъёог бие даасан хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжид ижил утгаар хэрэглэнэ. Бие даасан хөрөнгөнд хамаарах нэмэлт шаардлагуудыг 106-109-р параграфт, мөнгө бий болгогч нэгжид хамаарах нэмэлт шаардлагуудыг 110-111-р параграфт, гүүдвилд хамаарах нэмэлт шаардлагуудыг 111А-111Б параграфт тус тус заасан.
- (г) Хөрөнгийг мөнгө бий болгогч хөрөнгөөс мөнгө бий болгодоггүй хөрөнгө болгох эсвэл мөнгө бий болгодоггүй хөрөнгөөс мөнгө бий болгогч хөрөнгө болгох дахин ангиллын шаардлагуудыг 112-113-р параграфт заасан.
- (д) Хөрөнгө ба мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарз болон үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын талаархи тодруулга хийх мэдээллийг 114-122А параграфт тусгайлан заасан. Үнэ цэнийн бууралтыг нь сорьж шалгах зорилгоор тэдгээрт гүүдвилийг эсвэл тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хуваарилдаг тийм мөнгө бий болгогч нэгжүүдийн талаархи тодруулгын нэмэлт шаардлагуудыг 123-125-р параграфт заасан.

...

23. Үнэ цэнийн бууралтын ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхээс үл хамааран байгууллага нь мөн дараах зүйлсийг гүйцэтгэнэ:

(а) Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө эсвэл ашиглахад хараахан бэлэн болоогүй биет бус хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүнтэй зэрэгцүүлснээр үнэ цэнийн бууралтыг жил бүр сорьж шалгах. Хэрэв энэхүү үнэ цэнийн бууралтын сорилыг жил бүрийн нэг ижил хугацаанд хийдэг бол жилийн турш дахь дурын хугацаанд үүнийг гүйцэтгэж болно. Харин өөр өөр биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг өөр өөр хугацаанд сорьж шалгаж болно. Гэхдээ ийм биет бус хөрөнгийг тайлант жилийн дундуур анх хүлээн зөвшөөрсөн бол тэрхүү биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тухайн тайлант жилийн эцэс болохоос өмнө сорьж шалгана.

(б) Улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн гүүдвилийн үнэ цэнийн бууралтыг 90А-90Р параграфын дагуу жил бүр сорьж шалгах.

...

### **~~Бие даасан хөрөнгүүдийн~~ Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих**

71. Гүүдвилээс бусад, бие даасан хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг 72-75-р параграфт заасан. Мөнгө бий болгогч нэгж болон гүүдвилийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих талаар 76-98И параграфт авч үзсэн.

...

### **Мөнгө бий болгогч нэгжүүд ба гүүдвил**

76. Хөрөнгийн харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийг тогтоох, уг мөнгө бий болгогч нэгжүүд болон гүүдвилийн дансны үнийг тодорхойлох, тэдгээрийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх талаархи шаардлагуудыг 77-97И параграфт тусгасан.

...

### **Мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн ба дансны үнэ**

...

88. Нөхөгдөх дүнг үнэлэх зорилгоор хөрөнгүүдийг бүлэглэдэг тохиолдолд, холбогдох мөнгөн орлогын гүйлгээг бий болгодог буюу ингэж бий болгоход ашиглагдах бүх хөрөнгүүдийг уг мөнгө бий болгогч нэгжид багтаан оруулах нь чухал ач холбогдолтой юм. Хэрэв тэгэхгүй бол тухайн

мөнгө бий болгогч нэгж нь бүрэн нөхөгдөх мэт харагдах боловч үнэн хэрэгтээ үнэ цэнийн бууралтын гарз үүссэн байж болох юм. Мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг болох бие даасан хөрөнгүүдийн тайлагналыг үлгэрчлэн харуулсан блок схемийг Үлгэрчилсэн Шийдвэрийн Модонд харуулсан. Зарим тохиолдолд хэдийгээр тодорхой хөрөнгүүд нь мөнгө бий болгогч нэгжийн тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээнд хувь нэмрээ оруулдаг боловч тэдгээрийг үл үндэслэлтэй, тогтвортой сууриар уг мөнгө бий болгогч нэгжид хуваарилах боломжгүй байдаг. Гүүдвилийн хувьд ийм тохиолдол үүсэж болно. Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах үедээ эдгээр хөрөнгийг хэрхэн авч үзэхийг 90А-90Р параграфт тайлбарласан.

...

### Гүүдвил

Мөнгө бий болгогч нэгжүүдэд гүүдвилийг хуваарилах

90А. Үнэ цэнийн бууралтын сорил хийх зорилгын хувьд, улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн гүүдвилийг уг нэгдлийн өргөжилтийн хэмнэлтээс үр өгөөж олохоор хүлээгдэж буй тухайн нэгтгэгчийн мөнгө бий болгогч нэгж буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг нэг бүрд тэрхүү худалдан авалтын өдрөөс эхлэн хуваарилна. Энэ нь тухайн нэгдэж буй үйл ажиллагааны бусад хөрөнгө буюу өр төлбөрийг тэдгээр мөнгө бий болгогч нэгж буюу нэгжүүдийн бүлэгт хуваарилсан эсэхээс үл хамаарна. Мөнгө бий болгодоггүй үйл ажиллагааны худалдан авалтаар гүүдвилийг олж эзэмшсэн бөгөөд энэ нь нэгтгэгчийн цэвэр мөнгөн зарлагыг бууруулах үр дүнтэй байх тохиолдолд уг нэгтгэгчийг мөнгө бий болгогч нэгж гэж үзнэ. Гүүдвил нь мөнгө бий болгодоггүй үйл ажиллагааны худалдан авалттай холбоотой байхаас бусад тохиолдолд уг гүүдвилийг ингэж хуваарилах нэгж буюу нэгжүүдийн бүлэг нэг бүр нь:

- (а) дотоод удирдлагын зорилгоор уг гүүдвилийг хянан үнэлэх тухайн байгууллагын доторх хамгийн доод түвшинг төлөөлөн илэрхийлнэ; ба
- (б) УСНББОУС 18, Сегментийн Тайлагнал-ын 9-р параграфтаар тодорхойлсон, сегментээс том биш байна.

90Б. Худалдан авалтаар хүлээн зөвшөөрсөн гүүдвил нь тухайн нэгдлээр олж эзэмшсэн бусад хөрөнгүүдээс бий болох бөгөөд бие даасан байдлаар тодорхойлж, тусдаа хүлээн зөвшөөрөх боломжгүй эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлдэг хөрөнгө юм. Гүүдвил нь бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгээс хамааралгүй байдлаар мөнгөн орлогын гүйлгээг бий болгохгүй эсвэл цэвэр мөнгөн зарлагын гүйлгээг бууруулахгүй боловч мөнгө бий болгогч олон нэгжүүдийн мөнгөн гүйлгээнд ямагт хувь нэмрээ оруулдаг. Зарим үед гүүдвилийг бие даасан мөнгө бий болгогч нэгжүүдэд санамсаргүй тохиолдлын шинжтэйгээс өөр бусад сууриар

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

хуваарилах боломжгүй байдаг боловч мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлгүүдэд ингэж хуваарилах боломжтой юм. Иймээс дотоод удирдлагын зорилгоор гүүдвилийг хянан үнэлэх тухайн байгууллага доторх хамгийн доод түвшин нь уг гүүдвилд хамааралтай боловч гүүдвилийг хуваарилж болохгүй, мөнгө бий болгогч олон нэгжүүдээс зарим үед бүрддэг. Гүүдвилийг хуваарилах мөнгө бий болгогч нэгжийн талаархи 90Г-90Р болон 97А-97И параграф дахь хэллэгүүдийг гүүдвилийг хуваарилах мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг гэсэн утгаар ойлгож үнших хэрэгтэй. Нэгтгэгчийн цэвэр мөнгөн зарлагын гүйлгээг бууруулах үр дүнтэй, мөнгө бий болгодоггүй үйл ажиллагааны худалдан авалтаар гүүдвилийг олж эзэмшсэн тохиолдолд гүүдвилийг хуваарилах мөнгө бий болгогч нэгжийн талаархи 90Г-90Р болон 97А-97И параграф дахь хэллэгүүдийг тухайн нэгтгэгч гэсэн утгаар бас ойлгож үнших хэрэгтэй.

90В. 90А параграф дахь шаардлагуудыг даган мөрдөх нь байгууллага өөрийн үйл ажиллагааг удирдан зохицуулдаг болон угаасаа гүүдвилтэй холбоотой байх тийм арга замыг тусган илэрхийлэх түвшинд гүүдвилийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгахад хүргэнэ. Иймээс тайлагналын нэмэлт системийг хөгжүүлэн боловсруулах үндсэндээ шаардлагагүй юм.

90Г. Үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах зорилгоор гүүдвилийг хуваарилах мөнгө бий болгогч нэгж нь гадаад валютын олз, гарзыг хэмжих зорилгоор УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-ний дагуу гүүдвилийг хуваарилах түвшинтэй нийцэн тохирохгүй байж болно. Жишээлбэл; гадаад валютын олз, гарзыг хэмжих зорилгоор гүүдвилийг харьцангуй доод түвшингүүдэд хуваарилахыг УСНББОУС 4-өөр уг байгууллагаас шаарддаг байлаа гэхэд дотоод удирдлагын зорилгоор гүүдвилийг ийм түвшинд мөн хянан үнэлдэгээс бусад тохиолдолд үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвилийг үүнтэй ижил түвшинд сорьж шалгах шаардлагагүй юм.

90Д. **Хэрэв улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн гүүдвилийн анхны хуваарилалтыг тухайн нэгдлийн хүчин төгөлдөр болсон тайлант жилийн эцсээс өмнө бүрэн хийж чадаагүй бол нэгдлийн өдрөөс хойш эхлэх үг эхний тайлант жилийн эцэс болохоос өмнө тэрхүү анхны хуваарилалтыг хийж дуусгана.**

90Е. УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн дагуу хэрэв уг нэгдлийн анхны нягтлан бодох бүртгэлийг тэрхүү нэгдэл хүчин төгөлдөр болсон тухайн тайлант үеийн эцсээр зөвхөн урьдчилсан нөхцөлт байдлаар тодорхойлж чадахаар бол нэгтгэгч нь:

(а) Тэдгээр урьдчилсан нөхцөлт үнэ цэнийг ашигласнаар уг нэгдлийг тайлагнана; ба

(б) Нэгдлийн өдрөөс хойш 12 сараас илүүгүй байх хэмжилтийн хугацааны дотор уг анхны нягтлан бодох бүртгэлийг хийж дуусгасны үр дүнд тэдгээр урьдчилсан нөхцөлт үнэ цэнэд хийгдэх аливаа тохируулгыг хүлээн зөвшөөрнө.

Ийм нөхцөл байдалд уг нэгдэл хүчин төгөлдөр болсон тайлант жилийн эцсээс өмнө тухайн нэгдлээр хүлээн зөвшөөрсөн гүүдвилийн анхны хуваарилалтыг мөн хийж дуусгах боломжгүй байж болно. Энэ тохиолдолд байгууллага нь 122А параграфтаар шаардсан мэдээллийг тодруулна.

90Ж. Гүүдвилийг мөнгө бий болгогч нэгжид хуваарилсан бөгөөд байгууллага нь тухайн мөнгө бий болгогч нэгжид багтсан үйл ажиллагааг данснаас хассан бол уг данснаас хассан үйл ажиллагаатай холбоотой гүүдвил нь:

(а) Данснаас хасалтын олз, гарзыг тодорхойлох үед тухайн үйл ажиллагааны дансны үнэд багтана; ба

(б) Тухайн данснаас хассан үйл ажиллагаатай холбоотой гүүдвилийг илүү сайн тусган илэрхийлэх өөр бусад аргыг уг байгууллага харуулж чадахгүй бол мөнгө бий болгогч нэгжийн үлдсэн хэсгийн болон данснаас хассан үйл ажиллагааны харгалзах харьцангуй үнэ цэнээр хэмжигдэнэ.

90И. Хэрэв байгууллага нь гүүдвилийг хуваарилсан нэг буюу хэд хэдэн мөнгө бий болгогч нэгжүүдийн бүрэлдэхүүнийг өөрчлөх замаар өөрийн тайлагналын бүтцийг өөрчилж байгаа бол тэдгээр өөрчлөлтөнд орох нэгжүүдэд гүүдвилийг дахин хуваарилна. Байгууллага нь тухайн бүтцийн өөрчлөлт хийсэн нэгжүүдтэй холбоотой гүүдвилийг илүү сайн тусган илэрхийлэх өөр бусад арга замыг харуулж чадахгүй бол мөнгө бий болгогч нэгжийн доторх үйл ажиллагааг данснаас хасах үед хэрэглэсэнтэй адил харьцангуй үнэ цэнийн аргыг ашиглан энэхүү дахин хуваарилалтыг хийнэ.

Гүүдвил бүхий мөнгө бий болгогч нэгжүүдийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах

90К. 90Б параграфт дурдсанчлан, гүүдвил нь мөнгө бий болгогч нэгжтэй холбоотой боловч түүнийг тэрхүү нэгжид хуваарилаагүй байх үед уг нэгжийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа бол аливаа гүүдвилийг агуулаагүй тухайн нэгжийн дансны үнийг түүний нөхөгдөх дүнтэй зэрэгцүүлснээр энэхүү нэгжийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгана. Үнэ цэнийн бууралтын аливаа гарзыг 91-р параграфт заасны дагуу хүлээн зөвшөөрнө.

90Л. 90К параграфт дурдсан, мөнгө бий болгогч нэгж нь тодорхой бус ашиглалтын хугацаатай эсвэл ашиглахад хараахан бэлэн болоогүй байгаа биет бус хөрөнгийг өөрийн дансны үнэдээ агуулдаг бөгөөд тэрхүү хөрөнгийг зөвхөн уг мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг байдлаар үнэ цэнийн бууралтын хувьд сорьж шалгаж болохоор бол тухайн нэгжийн үнэ цэнийн бууралтыг мөн жил бүр сорьж шалгахыг 23-р параграфтаар шаардсан байдаг.

90М. Гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа тохиолдолд

гүүдвилийг агуулсан тухайн нэгжийн дансны үнийг түүний нөхөгдөх дүнтэй зэрэгцүүлснээр уг нэгжийн үнэ цэнийн бууралтыг жил бүр сорьж шалгана. Хэрэв нэгжийн нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс илүү байвал уг нэгж, түүнчлэн түүнд хуваарилсан гүүдвилийн үнэ цэнэ буураагүй гэж үзнэ. Хэрэв нэгжийн дансны үнэ нь түүний нөхөгдөх дүнгээс илүү байвал байгууллага нь 91-р параграфын дагуу үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө.

Үнэ цэнийн бууралтын сорилын хугацаа

90Н. Хэрэв гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын жил тутмын сорилыг жил бүрийн тодорхой нэг ижил хугацаанд хийдэг бол жилийн турш дахь дурын хугацаанд үүнийг гүйцэтгэж болно. Харин мөнгө бий болгогч өөр өөр нэгжүүдийн үнэ цэнийн бууралтыг өөр өөр хугацаанд сорьж шалгаж болно. Гэхдээ мөнгө бий болгогч нэгжид хуваарилсан зарим буюу бүх гүүдвилийг тухайн тайлант жилийн туршид улсын секторын нэгдлээр олж авсан бол тэрхүү нэгжийн үнэ цэнийн бууралтыг тухайн тайлант жилийн эцэс болохоос өмнө сорьж шалгана.

90О. Хэрэв гүүдвилийг хуваарилсан уг мөнгө бий болгогч нэгжийг бүрдүүлж байгаа хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг тухайн гүүдвилийг агуулж буй нэгжийн хугацаатай ижил хугацаанд сорьж шалгадаг бол тэрхүү гүүдвилийг агуулсан нэгжээс өмнө эдгээр хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгана. Үүнтэй адилаар, хэрэв гүүдвилийг хуваарилсан уг мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлгийг бүрдүүлж байгаа мөнгө бий болгогч нэгжүүдийн үнэ цэнийн бууралтыг тухайн гүүдвилийг агуулж буй нэгжүүдийн бүлгийн хугацаатай ижил хугацаанд сорьж шалгадаг бол тэрхүү гүүдвилийг агуулсан нэгжүүдийн бүлгээс өмнө эдгээр бие даасан нэгжүүдийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгана.

90П. Гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах үед тухайн гүүдвилийг агуулж буй нэгжийн доторх хөрөнгийн үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрч болох юм. Энэ тохиолдолд байгууллага нь эхлээд уг хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах ба уг гүүдвилийг агуулж буй мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгахын өмнө тухайн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын аливаа гарзыг хүлээн зөвшөөрнө. Үүнтэй адилаар, гүүдвилийг агуулж буй мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлгийн доторх тодорхой нэг мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрч болох юм. Энэ тохиолдолд байгууллага нь эхлээд уг мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах ба уг гүүдвилийг хуваарилах мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлгийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгахын өмнө тухайн нэгжийн хувьд үнэ цэнийн бууралтын аливаа гарзыг хүлээн зөвшөөрнө.

90Р. Гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнгийн талаар өмнөх тайлант үед хийсэн, хамгийн сүүлийн

нарийвчилсан тооцооллыг хэрэв дараах бүх шалгуур хангагдаж байвал уг нэгжийн тайлант үеийн үнэ цэнэ бууралтын сорилд ашиглаж болох юм:

- (a) Тухайн мөнгө бий болгогч нэгжийг бүрдүүлж буй хөрөнгө, өр төлбөр нь нөхөгдөх дүнгийн хамгийн сүүлийн тооцооллоос хойш мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй;
- (б) Нөхөгдөх дүнгийн хамгийн сүүлийн тооцоолол нь тухайн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнээс мэдэгдэхүйц өндөр дүнг харуулсан; ба
- (в) Нөхөгдөх дүнгийн хамгийн сүүлийн тооцооллоос хойш гарч тохиолдсон үйл явдлууд болон өөрчлөгдсөн нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн авч үзэхэд одоогийн нөхөгдөх дүн нь тухайн мөнгө бий болгогч нэгжийн одоогийн дансны үнээс бага болох магадлал маш бага байх.

### **Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарз**

91. Мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн нь уг нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) дансны үнээс бага байх зөвхөн тийм тохиолдолд мөнгө бий болгогч нэгжийн (гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжүүдийн хамгийн бага бүлгийн) хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө. Тухайн нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) мөнгө бий болгогч хөрөнгүүдийн дансны үнийг бууруулахын тулд үнэ цэнийн бууралтын гарзыг дараах дарааллаар хуваарилна:

- (a) Эхлээд, уг мөнгө бий болгогч нэгжид (нэгжүүдийн бүлэгт) хуваарилсан аливаа гүүдвилийн дансны үнийг бууруулах; ба
- (б) Дараа нь, тухайн нэгж (нэгжүүдийн бүлэг) дэх хөрөнгө тус бүрийн дансны үнэд үндэслэн хувь тэнцүүлсэн байдлаар нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) бусад хөрөнгөд хуваарилан бууруулах.

Дансны үнийн эдгээр бууралтыг бие даасан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз байдлаар авч үзэх бөгөөд 73-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө.

92. 91-р параграфын дагуу үнэ цэнийн бууралтын гарзыг хуваарилахдаа, байгууллага нь тухайн хөрөнгийн дансны үнийг дараах дүнгүүдийн аль өндрөөс бага болтол бууруулж болохгүй:

- (a) Түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ (хэрэв тодорхойлох боломжтой бол);
- (б) Түүний ашиглалтын үнэ цэнэ (хэрэв тодорхойлох боломжтой бол); ба
- (в) Тэг (0).



**Тухайн хөрөнгөнд хуваарилагдаагүй үлдсэн үнэ цэнийн бууралтын гарзын дүнг уг нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) бусад хөрөнгөнд хувь тэнцүүлэн хуваарилна.**

...

~~96. Хөрөнгө нь мөнгө бий болгодоггүй үйл ажиллагаанд бус, харин мөнгө бий болгогч нэг буюу хэд хэдэн үйл ажиллагаанд өөрийн үйлчилгээний чадавхийг шилжүүлдэг бол байгууллага нь ийм нөхцөл байдлыг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний хэлбэгдэх стандартыг лавлагаа болгоно.~~

...

**Гүүдвил ба хяналтын бус хувь оролцоо бүхий мөнгө бий болгогч нэгжүүдийн үнэ цэнийн бууралтын сорил**

97A. УСНББОУС 40-ийн дагуу нэгтгэгч нь уг нэгдлийн өдрөөр гүүдвилийг доорх (б)-д дурдсан дүнгээс (а)-д дурдсан дүнгийн давж гарсан илүү зөрүүгээр хэмжиж, хүлээн зөвшөөрнө:

(а) дараах зүйлсийн нийлбэр:

(i) УСНББОУС 40-ийн дагуу хэмжсэн тухайн шилжүүлсэн төлбөр, тэрхүү төлбөр нь ерөнхийдөө уг нэгдлийн өдрөөрх бодит үнэ цэнэ байхыг шаарддаг;

(ii) УСНББОУС 40-ийн дагуу хэмжсэн, уг худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцооны дүн; ба

(iii) Үе шаттайгаар хүрсэн нэгдлийн тохиолдолд, уг худалдан авсан үйл ажиллагааны хувьд нэгтгэгчийн өмнө эзэмшиж байсан өмчийн хувь оролцооны тухайн нэгдлийн өдрөөрх бодит үнэ цэнэ.

(б) УСНББОУС 40-ийн дагуу хэмжсэн, уг олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн тухайн нэгдлийн өдрөөрх цэвэр дүн.

*Гүүдвилийн хуваарилалт*

97Б. Энэ Стандартын 90А параграф нь тухайн худалдан авсан үйл ажиллагаанд хамаарах бусад хөрөнгө буюу өр төлбөрийг тэрхүү нэгтгэгчийн мөнгө бий болгогч нэгжүүд буюу нэгжүүдийн бүлгүүдэд хуваарилсан эсэхээс үл хамааран уг нэгдлээр хүлээн авсан гүүдвилийг мөнхүү улсын секторын нэгдлийн өргөжилтийн хэмнэлтээс үр өгөөж олохоор хүлээгдэж буй нэгтгэгчийн мөнгө бий болгогч нэгж буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг нэг бүрд хуваарилахыг шаарддаг. Хяналтын хувь бус хувь эзэмшигч нь өмчлөлийн оролцоогүй тийм мөнгө

бий болгогч нэгжид энэхүү улсын секторын нэгдлээс үүссэн зарим өргөжилтийн хэмнэлтийг хуваарилах боломжтой байдаг.

Үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах

97В. Үнэ цэнэ бууралтыг сорьж шалгахдаа мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг түүний дансны үнэтэй зэрэгцүүлэн үздэг.

97Г. Хэрэв байгууллага нь хяналтын бус хувь оролцоог бодит үнэ цэнээр биш, харин тухайн нэгдлийн худалдан авалтын өдрөөрх уг хяналтанд буй байгууллагын тодорхойлж болох цэвэр хөрөнгө дэх хувь тэнцүүлсэн хувь оролцоо байдлаар хэмждэг бол энэхүү хяналтын бус хувь оролцоонд хамаарах гүүдвилийг холбогдох мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнд оруулах боловч хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй. Иймээс байгууллага нь хяналтын бус хувь оролцоонд хамаарах гүүдвилийг тусган оруулахын тулд тухайн мөнгө бий болгогч нэгжид хуваарилсан гүүдвилийн дансны үнийг нэмж тооцно. Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохын тулд энэхүү тохируулсан дансны үнийг дараа нь тухайн нэгжийн нөхөгдөх дүнтэй зэрэгцүүлж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын гарзыг хуваарилах

97Д. 91-р параграф нь аливаа тодорхойлсон үнэ цэнийн бууралтын гарзыг эхлээд тухайн мөнгө бий болгогч нэгжид хуваарилагдсан гүүдвилийн дансны үнийг бууруулах, дараа нь уг нэгж дэх бусад хөрөнгө тус бүрийн дансны үнэд хувь тэнцүүлэн тэдгээр хөрөнгийн дансны үнийг бууруулах байдлаар хуваарилахыг шаарддаг.

97Е. Хэрэв хяналтанд буй байгууллага эсвэл хяналтын бус хувь оролцоо бүхий уг хяналтанд буй байгууллагын нэг хэсэг нь өөрөө мөнгө бий болгогч нэгж бол үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлыг хуваарилдагтай ижил сууриар тухайн хяналт тавигч байгууллага болон хяналтын бус хувь оролцоонд хуваарилна.

97Ж. Хэрэв хяналтанд буй байгууллага эсвэл хяналтын бус хувь оролцоо бүхий уг хяналтанд буй байгууллагын нэг хэсэг нь мөнгө бий болгогч арай том нэгжийн нэг хэсэг бол гүүдвилийн үнэ цэнийн бууралтын гарзыг тэрхүү мөнгө бий болгогч нэгжийн хяналтын бус хувь оролцоотой хэсэг ба тийм хувь оролцоогүй хэсгүүдэд хуваарилна. Үнэ цэнийн бууралтын гарзыг мөнгө бий болгогч нэгжийн хэсгүүдэд дараах зүйлд үндэслэн хуваарилна. Үүнд:

(а) Үнэ цэнийн бууралт нь мөнгө бий болгогч нэгж дэх гүүдвилд хамаарах хэмжээгээр тухайн үнэ цэнийн бууралтын өмнөх тэдгээр хэсгүүдийн гүүдвилийн холбогдох дансны үнэд; ба

(б) Үнэ цэнийн бууралт нь мөнгө бий болгогч нэгж дэх тодорхойлж болох хөрөнгүүдэд хамаарах хэмжээгээр тухайн үнэ цэнийн бууралтын өмнөх тэдгээр хэсгүүдийн тодорхойлж болох цэвэр

хөрөнгийн холбогдох дансны үнэд. Ийм аливаа ийм үнэ цэнийн бууралтыг уг хэсэг дэх хөрөнгө тус бүрийн дансны үнэд хувь тэнцүүлэн тухайн мөнгө бий болгогч нэгж бүрийн тэдгээр хэсгүүдийн хөрөнгүүдэд хуваарилна.

Хяналтын бус хувь оролцоотой тэдгээр хэсгүүдийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлыг хуваарилсантай ижил сууриар тухайн хяналт тавигч байгууллага болон хяналтын бус хувь оролцоонд хуваарилна.

97И. Хэрэв хяналтын бус хувь оролцоонд хамаарах үнэ цэнийн бууралтын гарз нь хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй гүүдвилтэй (97Г параграфыг үзнэ үү) холбоотой бол тэрхүү үнэ цэнийн бууралтыг гүүдвیلیйн үнэ цэнийн бууралтын гарз гэж хүлээн зөвшөөрөхгүй. Ийм тохиолдолд зөвхөн хяналт тавигч байгууллагад хуваарилсан гүүдвилтэй холбоотой үнэ цэнийн бууралтын гарзыг гүүдвیلیйн үнэ цэнийн бууралтын гарз гэж хүлээн зөвшөөрнө.

## **Үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах**

98. Хөрөнгө буюу мөнгө бий болгогч нэгжийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах шаардлагуудыг 99-105-р параграфт заасан. Эдгээр шаардлагуудад “хөрөнгө” гэсэн нэр томъёог ашигласан боловч энэ нэр томъёог бие даасан хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжид ижил утгаар хэрэглэнэ. Бие даасан хөрөнгөнд хамаарах нэмэлт шаардлагуудыг 106-109-р параграфт, мөнгө бий болгогч нэгжид хамаарах нэмэлт шаардлагуудыг 110 ба 111-р параграфт, гүүдвилд хамаарах нэмэлт шаардлагуудыг 111А ба 111Б параграфт тус тус заасан.

99. **Гүүдвилээс бусад** хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь цаашид оршин байгаа больсон буюу буурсан байж болох талаархи ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг байгууллага нь тайлант үе бүрийн эцэст үнэлнэ. Хэрэв ийм ямар нэг шинж тэмдэг оршин байвал байгууллага нь тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно.

100. **Гүүдвилээс бусад** хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь цаашид оршин байгаа больсон буюу буурсан байж болох талаархи ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэхдээ, уг байгууллага хамгийн наад зах нь дараах шинж тэмдгийг харгалзан үзнэ:

...

102. **Гүүдвилээс бусад** хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь цаашид оршин байгаа больсон буюу буурсан байж болох шинж тэмдэг байгаа бол хэдийгээр тухайн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг буцаагаагүй боловч энэ нь (а) хөрөнгийн ашиглалтын үлдсэн хугацаа, (б) элэгдлийн (хорогдуулгын) арга, (в)

хөрөнгийн үлдэх өртгийг дахин хянан үзэж, тухайн хөрөнгөнд хамаарах Стандартын дагуу тохируулах шаардлагатай гэдгийг илэрхийлж болох юм.

103. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрснөөс хойш тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орсон зөвхөн тийм тохиолдолд гүүдвилээс бусад хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана. Ингэж буцаахдаа 106-р параграфт зааснаас бусад тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүн хүртэл өсгөнө. Ийм өсөлт нь үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт юм.

...

### **Бие даасан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах**

106. Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтанд хамаарах гүүдвилээс бусад хөрөнгийн нэмэгдсэн дансны үнэ нь хэрэв тухайн хөрөнгийн хувьд өмнөх жилүүдэд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол тодорхойлогдох байсан дансны үнээс (элэгдэл буюу хорогдуулгыг хассан цэвэр дүнгээс) хэтрэх ёсгүй.
107. Хэрэв тухайн хөрөнгийн хувьд өмнөх жилүүдэд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол тодорхойлогдох байсан дансны үнээс (элэгдэл буюу хорогдуулгыг хассан цэвэр дүнгээс) давсан, гүүдвилээс бусад хөрөнгийн дансны үнийн аливаа өсөлт нь дахин үнэлгээ юм. Ийм дахин үнэлгээг тайлагнахдаа байгууллага нь тухайн хөрөнгөнд хамаарах холбогдох Стандартыг мөрдөнө.
108. Тухайн хөрөнгийг бусад Стандартын (жишээлбэл, УСНББОУС 17 ба УСНББОУС 31-д заасан дахин үнэлгээний загвар) дагуу түүний дахин үнэлсэн дүнгээр тайлагнаснаас бусад тохиолдолд гүүдвилээс бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын аливаа буцаалтыг тэрхүү бусад Стандартын дагуу дахин үнэлгээний нэмэгдэлтэй адилаар авч үзнэ.

...

### **Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах**

110. Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг тухайн нэгж дэх гүүдвилээс бусад хөрөнгүүдэд тэдгээр хөрөнгийн дансны үнээр хувь тэнцүүлэн хуваарилна. Дансны үнийн энэхүү өсөлтийг уг бие даасан хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт гэж үзэх бөгөөд 108-р параграфын дагуу хүлээн

зөвшөөрнө. Мөнгө бий болгогч нэгжид үйлчилгээний чадавхийн хувь нэмэр оруулдаг мөнгө бий болгодоггүй хөрөнгөнд ийм буцаалтын дүнгийн аливаа нэг хэсгийг хуваарилахгүй.

111. Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ бууралтын гарзын буцаалтыг 110-р параграфын дагуу хуваарилахдаа тухайн хөрөнгийн дансны үнийг дараах дүнгүүдийн аль багаас илүү болтол өсгөхгүй:

- (а) Түүний нөхөгдөх дүн (хэрэв тодорхойлох боломжтой бол); ба
- (б) Хэрэв уг хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол тодорхойлогдох байсан дансны үнэ (элэгдэл буюу хорогдуулгыг хассан цэвэр дүн).

Тухайн хөрөнгөнд хуваарилагдаагүй үлдсэн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын дүнг уг нэгжийн гүүдвилээс бусад хөрөнгүүдэд хувь тэнцүүлэн хуваарилна.

## Гүүдвилийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах

111А. Гүүдвилийн хувьд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг дараагийн тайлант үед буцаахгүй.

111Б. УСНББОУС 31 нь дотооддоо бий болгосон гүүдвилийг хүлээн зөвшөөрөхийг хориглодог. Тухайн гүүдвилийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрсний дараах тайлант үеүдэд гүүдвилийн нөхөгдөх дүнд гарсан аливаа өсөлт нь уг олж эзэмшсэн гүүдвилийн хувьд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт биш, харин дотооддоо бий болгосон гүүдвилийн өсөлт байх магадлалтай байдаг.

## Тодруулга

...

120. Байгууллага нь мөнгө бий болгогч хөрөнгө (үүн дотроо, гүүдвил) буюу мөнгө бий болгогч нэгжийн хувьд тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн эсвэл буцаасан материаллаг үнэ цэнийн бууралтын гарз тус бүрээр дараах зүйлсийг тодруулна:

- (а) Үнэ цэнэ бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлт эсвэл буцаалтанд хүргэсэн үйл явдлууд болон нөхцөл байдлууд;

...

- (д) Тухайн хөрөнгийн (мөнгө бий болгогч нэгжийн) нөхөгдөх дүн нь түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ эсвэл ашиглалтын үнэ цэнэ эсэх.

...

122. Байгууллага нь тухайн тайлант үеийн туршид хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлохын тулд ашигласан таамаглалуудаа тодруулахыг дэмжинэ. Гэвч тухайн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэд гүүдвил эсвэл тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө багтсан тохиолдолд уг мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг хэмжихдээ ашигласан тооцооллын талаархи мэдээллийг тодруулахыг тэрхүү байгууллагаас 123-р параграфтаар шаардсан байдаг.

122A. 90Д параграфт заасанчлан, тухайн тайлант үеийн туршид улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн гүүдвилийн аливаа нэг хэсгийг уг тайлант үеийн эцэст мөнгө бий болгогч нэгжид (нэгжүүдийн бүлэгт) хуваарилаагүй байвал тэрхүү хуваарилагдаагүй гүүдвилийн дүнг яагаад ингэж хуваарилаагүй үлдсэн шалтгааны хамт тодруулна.

**Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг агуулсан мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг хэмжихэд ашигласан тооцооллын тодруулга**

123. Тухайн мөнгө бий болгогч нэгжид (нэгжүүдийн бүлэгт) хуваарилсан гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн дансны үнэ нь уг байгууллагын гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнэтэй харьцуулахад мэдэгдэхүйц их байх тохиолдолд байгууллага нь тэдгээр мөнгө бий болгогч нэгж (нэгжүүдийн бүлэг) тус бүрийн хувьд доорх (a)-(д)(e)-д шаардсан мэдээллийг тодруулна:

(a) Тухайн мөнгө бий болгогч нэгжид (нэгжүүдийн бүлэгт) хуваарилсан гүүдвилийн дансны үнэ;

~~(a)~~(б) Тухайн мөнгө бий болгогч нэгжид (нэгжүүдийн бүлэгт) хуваарилсан тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн дансны үнэ;

~~(б)~~(в) Мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүнг тодорхойлсон суурь (өөрөөр хэлбэл, ашиглалтын үнэ цэнэ эсвэл борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ).

~~(в)~~(г) Хэрэв мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэд үндэслэсэн бол:

(i) Хамгийн сүүлийн төсөв/прогнозын хамрах тухайн тайлант үеийн хувьд удирдлага нь өөрийн мөнгөн гүйлгээний төсөвлөлтийн үндэслэл болгосон гол таамаглал нэг бүрийн тайлбар тодорхойлолт. Гол таамаглал гэдэг нь тухайн мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн хамгийн их хамааралтай, мэдрэмтгий байх тийм таамаглалууд юм;

(ii) Гол таамаглал тус бүрд хамааруулан хуваарилсан үнэ цэнийг тодорхойлох удирдлагын арга хандлагын тайлбар тодорхойлолт. Эдгээр үнэ цэнэ нь өмнөх

туршлагыг тусгасан эсвэл зохих мэдээллийн гадаад эх сурвалжтай нийцэн тохирч байгаа эсэх, хэрэв тийм биш бол өмнөх туршлага эсвэл мэдээллийн гадаад эх сурвалжаас яагаад, хэр их өөр байгаа эсэх;

- (iii) Удирдлагын баталсан санхүүгийн төсөв/прогнозод үндэслэн мөнгөн гүйлгээг удирдлага төсөвлөн тооцсон тайлант хугацаа, тухайн мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) хувьд таван жилээс урт хугацааг ашигласан тохиолдолд яагаад ийм урт хугацаа тохиромжтой гэдгийг зөвтгөн баталсан тайлбар;
- (iv) Хамгийн сүүлийн төсөв/прогнозод хамаарах тайлант үеэс хойшхи хугацааны мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд экстраполяци (төсөөлөн тооцолт) хийхдээ ашигласан өсөлтийн хувь ба уг байгууллагын үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, түүний үйл ажиллагаагаа явуулдаг салбар, улс буюу улс орнууд, эсвэл тухайн мөнгө бий болгогч нэгжийг (нэгжүүдийн бүлгийг) ашигладаг зах зээлийн урт хугацааны өсөлтийн дундаж хувиас давсан аливаа өсөлтийн хувийг ашиглах үндэслэл;
- (v) Мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд ашигласан дискаунтын хувь;

(г)(д) Хэрэв мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэд үндэслэсэн бол уг борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг хэмжихдээ ашигласан үнэлгээний арга зүй. Хэрэв борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тухайн нэгжийн ажиглаж болох зах зээлийн үнийг ашиглан хэмжээгүй бол дараах мэдээллийг бас тодруулна:

- (i) Удирдлага нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тодорхойлохдоо үндэслэл болгосон гол таамаглал нэг бүрийн тайлбар тодорхойлолт. Гол таамаглал гэдэг нь тухайн мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн хамгийн их хамааралтай, мэдрэмтгий байх тийм таамаглалууд юм.
- (ii) Гол таамаглал тус бүрд хамааруулан хуваарилсан үнэ цэнийг (эсвэл үнэ цэнүүдийг) тодорхойлох удирдлагын арга хандлагын тайлбар тодорхойлолт. Эдгээр үнэ цэнэ нь өмнөх туршлагыг тусгасан эсвэл зохих мэдээллийн гадаад эх сурвалжтай нийцэн тохирч байгаа эсэх, хэрэв тийм биш бол өмнөх туршлага эсвэл мэдээллийн гадаад эх сурвалжаас яагаад, хэр их өөр байгаа эсэх.

Хэрэв борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг дискаунтчилсан мөнгөн гүйлгээний төсөвлөлт ашиглан хэмжсэн бол байгууллага нь дараах мэдээллийг бас тодруулна:

- (iii) Удирдлага нь мөнгөн гүйлгээг төсөвлөсөн тайлант хугацаа;
- (iv) Мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд экстраполяци хийхдээ ашигласан өсөлтийн хувь;
- (v) Мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд ашигласан дискаунтын хувь.

~~(д)~~(e) Хэрэв мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүнг тодорхойлохдоо удирдлагын үндэслэл болгосон гол таамаглалд гарах ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлт нь уг нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) дансны үнэ түүний нөхөгдөх дүнгээсээ хэтэрч, илүү гарахад хүргэж байвал:

- (i) Тухайн мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс хэтэрч, давсан дүн;
- (ii) Гол таамаглал тус бүрд хамааруулан хуваарилсан үнэ цэнэ;
- (iii) Мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн нь түүний дансны үнэтэй тэнцүү байхын тулд нөхөгдөх дүнг хэмжихэд ашигласан бусад хувьсагчдад уг өөрчлөлтийн үзүүлэх цаашдын аливаа үр нөлөөг нэгтгэн тооцсоны дараа тэрхүү гол таамаглалд хамааруулан хуваарилах үнэ цэнийн дүн өөрчлөгдөх ёстой.

124. Хэрэв гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгүүдийн бүх буюу зарим дансны үнийг мөнгө бий болгогч олон нэгжүүдэд (нэгжүүдийн бүлгүүдэд) дамжуулан хуваарилсан ба нэгж (нэгжүүдийн бүлэг) бүрд ингэж хуваарилсан дүн нь тухайн байгууллагын гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнэтэй харьцуулахад мэдэгдэхүйц их биш бол тэдгээр нэгжүүдэд (нэгжүүдийн бүлгүүдэд) хуваарилсан гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнийн хамтаар энэ тухай тодруулга хийнэ. Түүнчлэн, мөнгө бий болгогч нэгжүүдэд (нэгжүүдийн бүлгүүдэд) хуваарилсан гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнэд болон уг гол таамаглалуудад үндэслэсэн тэдгээр нэгжүүдийн (нэгжүүдийн бүлгүүдийн) нөхөгдөх дүн нь уг байгууллагын гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнэтэй харьцуулахад мэдэгдэхүйц их байвал байгууллага нь энэ тухай доорх зүйлсийн хамт тодруулна:

(a) Тэдгээр мөнгө бий болгогч нэгжүүдэд (нэгжүүдийн бүлгүүдэд) хуваарилсан гүүдвилийн нийт дансны үнэ;



- ~~(а)~~(б) Тэдгээр мөнгө бий болгогч нэгжүүдэд (нэгжүүдийн бүлгүүдэд) хуваарилсан тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнэ;
- ~~(б)~~(в) Гол таамаглалуудын тухай тайлбар тодорхойлолт;
- ~~(в)~~(г) Гол таамаглалуудад хамааруулан хуваарилсан үнэ цэнийг тодорхойлох удирдлагын арга хандлагын тайлбар тодорхойлолт. Эдгээр үнэ цэнэ нь өмнөх туршлагыг тусгасан эсвэл зохих мэдээллийн гадаад эх сурвалжтай нийцэн тохирч байгаа эсэх, хэрэв тийм биш бол өмнөх туршлага эсвэл мэдээллийн гадаад эх сурвалжаас яагаад, хэр их өөр байгаа эсэх;
- ~~(г)~~(д) Хэрэв гол таамаглалд гарах ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлт нь уг мөнгө бий болгогч нэгжүүдийн (нэгжүүдийн бүлгүүдийн) дансны үнэ тэдгээрийн нөхөгдөх дүнгээсээ хэтэрч, илүү гарахад хүргэж байвал:
- (i) Тухайн мөнгө бий болгогч нэгжүүдийн (нэгжүүдийн бүлгүүдийн) нийт нөхөгдөх дүн нь тэдгээрийн дансны үнээс хэтэрч, давсан дүн;
  - (ii) Гол таамаглал тус бүрд хамааруулан хуваарилсан үнэ цэнэ;
  - (iii) Мөнгө бий болгогч нэгжүүдийн (нэгжүүдийн бүлгүүдийн) нийт нөхөгдөх дүн нь тэдгээрийн нийт дансны үнэтэй тэнцүү байхын тулд нөхөгдөх дүнг хэмжихэд ашигласан бусад хувьсагчдад уг өөрчлөлтийн үзүүлэх цаашдын аливаа үр нөлөөг нэгтгэн тооцсоны дараа тэрхүү гол таамаглалд хамааруулан хуваарилах үнэ цэнийн дүн өөрчлөгдөх ёстой.

125. Мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүнгийн хувьд өмнөх тайлант үед хийсэн, хамгийн сүүлийн дэлгэрэнгүй тооцоолол нь хэрэв тусгайлан заасан шалгуурыг хангаж байвал 37 буюу 90P параграфын дагуу тэдгээрийг дараагийн тайлант үед шилжүүлж, тухайн тайлант үед уг нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) үнэ цэнийн бууралтыг сориход ашиглаж болно. Ингэж шилжүүлэн ашиглах тохиолдолд 123 ба 124-р параграфуудад шаардсан тодруулгад тусгасан уг нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) талаархи мэдээлэл нь нөхөгдөх дүнгийн хувьд хийж, өмнөх тайлант үеэс шилжүүлэн авсан тооцоололтой холбоотой байна.

## Хүчин төгөлдөр болох хугацаа

...

126Л. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 2, 23, 71, 76, 88, 91, 92, 98-100, 102, 103, 106-108, 110, 111, 120, 122, 123-125-р параграфуудад нэмэлт өөрчлөлт

оруулж, 18А, 20А, 90А-90Р, 97А-97И, 111А, 111Б, 122А параграфуудыг шинээр нэмсэн ба 7, 96-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 26-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

**НББОУС3-ийн 2004 онд гаргасан, НББОУС 36-гийн хянан засварласан хувилбарт үндэслэн УСНББОУС 26-г боловсруулсан.**

...

*Гүүдвилийг энэ Стандартын цар хүрээнд хамруулахгүй байх*

ДҮ8. НББОУС 36 нь (а) гүүдвилийн үнэ цэнийн бууралт, (б) гүүдвилийг мөнгө бий болгогч нэгжүүдэд хуваарилалт, (в) гүүдвил бүхий мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын сорилын талаархи дэлгэрэнгүй шаардлага ба заавар удирдамжийг агуулсан байдаг. УСНББОУС 26-г боловсруулах үедээ УСНББОУС3 нь энэхүү Стандартын цар хүрээнд гүүдвилийг хамааруулах хэрэгтэй эсэхийг харгалзан үзсэн. УСНББОУС3 нь улсын секторын байгууллагын нэгдлийг зохицуулах УСНББОУС-ыг хараахан гаргаагүй байсан бөгөөд улсын секторын байгууллагуудын нэгдэл хийгдсэн тохиолдолд улсын секторын олон тооны тусгай асуудлууд үүсэх магадлалтай гэж үзсэн. Тухайлбал; улсын секторын байгууллагуудын нэгдлийн хувьд нэгтгэгчийг тодорхойлж чадах эсэх. УСНББОУС3 нь гүүдвилийг энэхүү Стандартын цар хүрээнд хамруулах хэрэггүй гэж үзсэн. Гүүдвилийн үнэ цэнийн бууралт, мөнгө бий болгогч нэгжүүдэд гүүдвилийн хуваарилалт, гүүдвил бүхий мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын сорилыг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудын шаардлагуудыг хэрглэгчид нь УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого*, *Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт* ба *Алдаа*-нд заасан эрэмбэ дарааллын лавлагаа болгон харгалзан үзнэ.

ДҮ8А. УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийг 2017 оны 01 дүгээр сард гаргасан. УСНББОУС 40 нь гүүдвилийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг агуулсан байдаг. УСНББОУС 40-ийг боловсруулахдаа, УСНББОУС3 нь гүүдвиллийн үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг харгалзан үзсэн. Гүүдвилл нь бусад хөрөнгүүдээс бие даасан байдлаар

эдийн засгийн үр өгөөж бий болгодоггүй, иймээс хөрөнгүүдийн бүлгийн нэг хэсэг байдлаар түүний үнэ цэнийн бууралтыг үнэлнэ гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэдэг. Эерэг мөнгөн орлогын гүйлгээ эсвэл цэвэр мөнгөн зарлагын гүйлгээний бууралт эсэхээс үл хамааран мөнгөн гүйлгээг зөвхөн лавлагаа болгосноор гүүдвиллийг хэмжиж болно. УСНББОУС 21 нь зөвхөн бие даасан хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг авч үздэг бөгөөд тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийг харгалзсанаар үнэ цэнийн бууралтыг үнэлдэг гэдгийг УСНББОУСЗ мөн тэмдэглэсэн байдаг. Иймээс УСНББОУСЗ нь гүүдвиллийн үнэ цэнийн бууралтанд УСНББОУС 21-ийг мөрдөх нь тохиромжгүй гэж дүгнэсэн. Гүүдвиллийн хамаарах үйл ажиллагаа нь мөнгө бий болгогч үйл ажиллагаа эсэхээс үл хамааран үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвиллийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзвэл зохино гэж УСНББОУСЗ дүгнэсэн. УСНББОУСЗ нь үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвиллийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзэх нэмэлт заавар удирдамжийг УСНББОУС 21 ба УСНББОУС 26-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

ДҮ8Б. Үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвиллийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзэх хэрэгтэй гэсэн УСНББОУСЗ-ийн шийдвэрийн үр дүн болгон УСНББОУСЗ нь (а) гүүдвиллийн үнэ цэнийн бууралт, (б) мөнгө бий болгогч нэгжүүдэд гүүдвиллийн хуваарилалт, (в) гүүдвил бүхий мөнгө бий болгогч нэгжүүдийг НББОУС 36-д заасан үнэ цэнийн бууралтын хувьд сорьж шалгалт зэргийн талаархи дэлгэрэнгүй шаардлагууд болон заавар удирдамжийг УСНББОУС 26-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 26-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

## **Данснаас хасах үйл ажиллагааны дансны үнэд гүүдвиллийг оруулах**

### Танилцуулга

ХЗУ24А. Гүүдвиллийг хуваарилсан уг мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг болох үйл ажиллагааг хотын захиргаа нь 100ТН-ээр борлуулсан. Тухайн нэгжид хуваарилсан гүүдвиллийг санамсаргүй тохиолдлын шинжтэй хуваарилахаас бусад тохиолдолд уг нэгжээс доод түвшний хөрөнгийн бүлэгт хамааруулах буюу хуваарилах боломжгүй байна. Уг мөнгө бий болгогч нэгжийн үлдэх хэсгийн нөхөгдөх дүн нь 300ТН байна.

### Нягтлан бодох бүртгэлийн хандлага

ХЗУ24Б. Мөнгө бий болгогч нэгжид хуваарилсан гүүдвиллийг тухайн нэгжээс доод түвшний хөрөнгийн бүлэгт санамсаргүй тохиолдлын шинжтэйгээс өөр бусад сууриар хамааруулах буюу хуваарилж чадахгүй учраас уг данснаас

хассан үйл ажиллагаа болон тухайн нэгжийн үлдсэн хэсгийн харьцангуй үнэ цэнүүдэд үндэслэн тэрхүү данснаас хассан үйл ажиллагаатай холбоотой гүүдвилийг хэмжинэ. Иймээс мөнгө бий болгогч нэгжид хуваарилсан гүүдвилийн 25 хувийг тухайн худалдан борлуулсан үйл ажиллагааны дансны үнэд хамааруулан оруулна.

## **Мөнгө бий болгогч нэгжийн бүтцийг өөрчилсөн үед гүүдвилийг дахин хуваарилах**

### Танилцуулга

ХЗУ24В. Гүүдвилийг мөнгө бий болгогч нэгж А-д өмнө нь хуваарилсан. А-д хуваарилсан уг гүүдвилийг санамсаргүй тохиолдлын шинжтэйгээс өөр бусад сууриар А-аас доод түвшний хөрөнгийн бүлэгт хамааруулах буюу хуваарилж чадахгүй. А нь задран хуваагдаж, Б, В, Г гэсэн мөнгө бий болгогч өөр гурван нэгжид нэгтгэгдсэн.

### Нягтлан бодох бүртгэлийн хандлага

ХЗУ24Г. А-д хуваарилсан гүүдвилийг санамсаргүй тохиолдлын шинжтэйгээс өөр бусад сууриар А-гаас доод түвшний хөрөнгийн бүлэгт хамааруулах буюу хуваарилж чадахгүй тул Б, В, Г-д нэгтгэхийн өмнөх А-гийн тэдгээр гурван хэсгийн харьцангуй үнэ цэнэд үндэслэн гүүдвилийг Б, В, Г нэгжүүдэд дахин хуваарилна.

## **НББОУС 36-тай харьцуулалт**

УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* нь улсын секторын мөнгө бий болгогч хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг авч үздэг бөгөөд 2008 оны 5 дугаар сард гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 36, *Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үүнд тусгасан болно. УСНББОУС 26 ба НББОУС 36-гийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

...

- ~~Гүүдвил нь УСНББОУС 26-гийн цар хүрээнд хамаардаггүй. НББОУС 36 нь гүүдвилийн үнэ цэнийн бууралт, мөнгө бий болгогч нэгжүүдэд гүүдвилийн хуваарилалт, гүүдвил бүхий мөнгө бий болгогч нэгжүүдийн үнэ цэнийн бууралтын сорилын талаархи дэлгэрэнгүй шаардлагууд болон заавар удирдамжийг агуулсан байдаг.~~

...

## **УСНББОУС 27, Хөдөө Аж Ахуй-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

48-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан ба 56Е параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### **Тодруулга**

#### **Ерөнхий зүйл**

...

48. Байгууллага нь тухайн тайлант үеийн эхэн ба эцсийн хооронд биологийн хөрөнгүүдийн дансны үнэд гарсан өөрчлөлтийн тохируулгын тайланг толилуулна. Тохируулгын тайланд дараах зүйлсийг тусгана:

...

- (ж) **Байгууллагын нэгдлийн Улсын секторын нэгдлийн үр дүнд нэмэгдсэн дүн;**

...

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

...

- 56Е. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 48-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## **УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

2, МЗУ35, МЗУ131, Б4-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан ба 125Ж параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

## Цар хүрээ

2. Бүх байгууллагууд нь доор дурдсанаас бусад бүх төрлийн санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:

...

- (е) Худалдан авч буй үйл ажиллагааг нэгтгэгчийг худалдан авах буюу худалдах талаар тухайн нэгтгэгч болон борлуулагчийн хооронд байгуулсан бөгөөд тэрхүү ирээдүйн худалдан авалтын өдөр улсын секторын нэгдэл байгууллагын нэгдэл үүсэхэд хүргэх аливаа форвард гэрээ. Форвард гэрээний хугацаа нь аливаа шаардлагатай зөвшөөрлийг олж авах ба тухайн ажил гүйлгээг хэрэгжүүлэхэд хэвийн шаардагдах ул үндэслэлтэй хугацаанаас хэтрэхгүй байвал зохино.

...

## Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 125Ж. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 2, МЗУ35, МЗУ131, Б4-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## Мөрдөх заавар удирдамж

*Энэ Хавсралт нь УСНББОУС 29-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

...

## Тодорхойлолт (9 ба 10-р параграф)

...

*Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт*

...

- МЗУ35. Дараах зүйлсийн аль нэгэнд хамааралтай бол дуусгавар болох хугацаанаас өмнөх борлуулалт нь 10-р параграфт заасан нөхцлийг

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

хангах бөгөөд ингэснээр бусад хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших уг байгууллагын санаа төлөвлөгөөний талаар эргэлзээ үүсгэхгүй:

...

- (в) Байгууллагын одоогийн хүүний түвшний эрсдлийн төлөв байдал буюу зээлийн эрсдлийн бодлогыг хадгалахын тулд дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг борлуулах эсвэл шилжүүлэхэд хүргэх улсын секторын томоохон нэгдэл байгууллагын нэгдэл эсвэл (сегментийн борлуулалт гэх мэт) томоохон данснаас хасалт (хэдийгээр улсын секторын нэгдэл байгууллагын нэгдэл нь тухайн байгууллагын хяналтанд буй үйл явдал боловч хүүний түвшний эрсдлийн төлөв байдал буюу зээлийн эрсдлийн бодлогыг хадгалахын тулд түүний хөрөнгө оруулалтын багцад оруулах өөрчлөлт нь урьдчилан таамагласан гэхээсээ үр дагаврын шинжтэй байж болно).

...

### **Хейж (80-113-р параграф)**

...

#### *Хейжийн зүйлс (87-94-р параграф)*

Шалгуур хангах хейжийн зүйлс (87-89-р параграф)

МЗУ131. Хейж хийгдэж буй бусад эрсдлүүдийг тусгайлан тодорхойлж, хэмжих боломжгүй учраас улсын секторын нэгдлээр байгууллагын нэгдлээр байгууллага буюу нэгдмэл цогц үйл ажиллагааг худалдан авах арилжааны баталгаа нь гадаад валютын ханшийн эрсдлээс бусад эрсдлийн хувьд хейжийн зүйл болж чадахгүй. Тэдгээр бусад эрсдэл нь ерөнхий үйл ажиллагааны эрсдэл юм.

## **Хавсралт Б**

### **Дагалдах үүсмэл хэрэглүүрийн дахин үнэлэлт**

*Энэ Хавсралт нь УСНББОУС 29-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

#### **Танилцуулга**

...

- Б4. Улсын секторын нэгдэл байгууллагын нэгдэл дэх дагалдах үүсмэл хэрэглүүр бүхий гэрээний олж эзэмшилт буюу тухайн олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн боломжит дахин үнэлэлтээс бусад, УСНББОУС 29-

ийн цар хүрээнд хамаарах бүх дагалдах үүсмэл хэрэглүүрийн хувьд энэ Хавсралтыг мөрдөнө.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 29-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

### **Хэсэг E: Хейж**

...

#### *E.2. Хейжийн зүйлс*

...

E.2.3. Хейжийн нягтлан бодох бүртгэл: Хадгаламжийн баазын биет бус хөрөнгө

**Хадгаламжийн баазын биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийн эрсдлийн хейжийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг зөвшөөрдөг үү?**

Энэ нь тэрхүү хадгаламжийн баазын биет бус хөрөнгийг дотооддоо бий болгосон эсвэл (жишээлбэл; улсын секторын нэгдлийн байгууллагын нэгдлийн нэг хэсэг байдлаар) худалдаж авсан эсэхээс хамаардаг.

## **УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

3, 6, 18, 24, 40, 41, 66, 67, 117-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 18А, 26А, 39А-39Д, 93А, 114А, 132К параграфыг шинээр нэмсэн бөгөөд 17, 39-р параграфын дараа нэмэлт гарчиг оруулсан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### **Цар хүрээ**

...

3. **Энэ Стандартыг доор дурдснаас бусад, биет бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэлд мөрдөнө:**

(а) **Бусад Стандартын цар хүрээнд хамаардаг биет бус хөрөнгө;**

...



~~(д) Бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн биет бус хөрөнгө (бизнесийн нэгдлийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний хөлбөгдөх стандартыг үзнэ үү);~~

~~(е) Бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн гүүдвил (бизнесийн нэгдлийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний хөлбөгдөх стандартыг үзнэ үү);~~

...

6. Хэрэв бусад Стандарт нь тодорхой нэг төрлийн биет бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг тодорхойлсон бол байгууллага нь энэ Стандартыг биш, харин тухайн хамаарах Стандартыг мөрдөнө. Тухайлбал, энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөхгүй:

...

(г) УСНББОУС 28-д тодорхойлсон санхүүгийн хөрөнгө. Зарим санхүүгийн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр Дэх Хөрөнгө Оруулалт*-д авч үзсэн байдаг; ба

(д) УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ийн цар хүрээнд хамаарах үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт ба анхны хэмжилт. Гэхдээ энэ Стандартыг ийм хөрөнгүүдийн дараагийн тайлант үеийн хэмжилт ба тодруулгад мөрдөнө; ба

(е) Гүүдвил (УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийг үзнэ үү).

...

## Тодорхойлолт

...

### Тодорхойлж болох байдал

18. 17-р параграфт дурдсан бүх зүйлс нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг, өөрөөр хэлбэл тодорхойлж болох, нөөцийг хянах, ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхитай байх гэсэн шинжүүдийг хангана гэсэн үг биш юм. Хэрэв энэ Стандартын цар хүрээнд хамаарах зүйл нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй бол уг зүйлийг худалдан авах эсвэл дотооддоо бий болгоход гаргасан зарлагыг түүнийг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө. Харин тухайн зүйлийг нэгдлийн үед олж авсан бол энэ нь уг нэгдлийн өдрөөр хүлээн зөвшөөрөх гүүдвیلیйн нэг хэсгийг бүрдүүлнэ (66-р параграфыг үзнэ үү).

18А. Биет бус хөрөнгийн тодорхойлолт нь түүнийг гүүдвилээс ялгахын тулд тодорхойлж болохуйц байхыг уг биет бус хөрөнгөөс шаарддаг. Нэгдлээр

хүлээн зөвшөөрсөн гүүдвил нь уг нэгдлээр олж авсан бусад хөрөнгүүдээс бий болох ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлэх боловч бие даасан байдлаар тодорхойлж, тусдаа хүлээн зөвшөөрөх боломжгүй хөрөнгө юм. Энэхүү ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь олж авсан тэдгээр тодорхойлж болох хөрөнгүүдийн өргөжилтийн хэмнэлтээс эсвэл санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шалгуурыг бие даан хангахгүй хөрөнгүүдээс үүсэж болох юм.

...

### *Хөрөнгийн хяналт*

...

24. Байгууллага нь өөрийн үйлчилгээний хэрэглэгчдийн багцтай буюу түүний үйлчилгээний зорилтот хэрэглэгчдэд хүрэх амжилтын хувь хэмжээтэй бөгөөд үйлчилгээний хэрэглэгчидтэй харилцаа тогтоох хүчин чармайлтын үр дүнд тэдгээр хэрэглэгч нар түүний үйлчилгээг ашигласан хэвээр байна гэсэн хүлээлттэй байж болох юм. Гэвч үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцаа болон тэдгээр хэрэглэгчдийн үнэнч, тууштай байдлыг хамгаалах хууль ёсны эрх буюу хяналт тавих бусад арга зам байхгүйн улмаас ийм зүйлс (жишээлбэл; үйлчилгээний хэрэглэгчдийн багц, зах зээлийн тодорхой хэсэг буюу үйлчилгээний амжилтын хувь хэмжээ, үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцаа ба тэдгээр хэрэглэгчдийн үнэнч, тууштай байдал) нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангахуйц тийм хангалттай хяналтыг уг байгууллага нь тухайн үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцаанаас болон хэрэглэгчдийн үнэнч, тууштай байдлаас бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид ихэвчлэн тавьж чаддаггүй. Ийм харилцааг хамгаалах хууль ёсны эрх байхгүй тохиолдолд адил буюу ижил төсөөтэй гэрээт бус үйлчлүүлэгчийн харилцаанд хамаарах (нэгдлийн нэг хэсэг байхаас бусад) арилжааны ажил гүйлгээ нь тухайн үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцаанаас бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг уг байгууллага хянах боломжтой хэвээр байна гэсэн нотолгоогоор хангадаг. Ийм арилжааны ажил гүйлгээ нь тухайн үйлчилгээний хэрэглэгчидтэй тогтоосон харилцааг салган тусгаарлаж болно гэсэн нотолгоогоор бас хангадаг учраас тэдгээр харилцаа нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангана.

...

### **Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт**

...

- 26А. Энэхүү хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг тусад нь худалдан авсан биет бус хөрөнгөнд мөрдөх талаар 32-39-р параграфт, улсын секторын

нэгдлээр олж авсан биет бус хөрөнгөнд мөрдөх талаар 39А-41-р параграфт тус тус авч үзсэн. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийн анхны хэмжилтийн талаар 42-43-р параграфт, биет бус хөрөнгийн солилцооны талаар 44-45-р параграфт, дотооддоо бий болгосон гүүдвилийн бүртгэлийг 46-48-р параграфт заасан. Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг 49-65-р параграфт авч үзсэн.

...

**Нэгдлийн (улсын секторын нэгдлийн) нэг хэсэг байдлаар биет бус хөрөнгийг олж эзэмших**

39А. УСНББОУС 40-ийн дагуу хэрэв биет бус хөрөнгийг нэгдлээр олж эзэмшсэн бол уг биет бус хөрөнгийн өртөг нь тухайн нэгдлийн өдрөөрх түүний бодит үнэ цэнэ байна. Биет бус хөрөнгийн бодит үнэ цэнэ нь тухайн хөрөнгөнд агуулагдсан, хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи уг байгууллагад орох магадлалын талаархи тэрхүү нэгдлийн өдрөөрх зах зээлд оролцогчдын хүлээлтийг тусгадаг. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орох хугацаа буюу дүн нь тодорхой бус байлаа ч гэсэн тухайн байгууллага нь уг эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орж ирнэ гэж хүлээдэг. Иймээс нэгдлээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийн хувьд 28(а) параграфт заасан магадлалт хүлээн зөвшөөрөлтийн шалгуур ямагт хангагдана гэж үздэг. Хэрэв нэгдлээр олж эзэмшсэн хөрөнгө нь тусдаа салгах боломжтой эсвэл заавал биелүүлэх хэлцлээс (үүн дотроо, гэрээний буюу хуулийн бусад эрхээс) үүссэн бол уг хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих хангалттай мэдээлэл оршин байдаг. Иймээс нэгдлээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийн хувьд 28(б) параграфт заасан найдвартай хэмжилтийн шалгуур ямагт хангагдана гэж үзнэ.

39Б. Худалдан авсан үйл ажиллагаагаар тухайн хөрөнгийг нэгдлээс өмнө хүлээн зөвшөөрч байсан эсэхээс үл хамааран нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааны биет бус хөрөнгийг энэхүү Стандарт болон УСНББОУС 40-ийн дагуу тэрхүү нэгдлийн өдрөөр гүүдвилээс тусад нь хүлээн зөвшөөрнө. Хэрэв уг худалдан авсан үйл ажиллагааны дуусаагүй судалгаа ба хөгжүүлэлтийн төсөл нь биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангаж байвал тухайн нэгтгэгч түүнийг гүүдвилээс тусад нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө гэсэн утгатай заалт юм. Худалдан авсан үйл ажиллагааны дуусаагүй судалгаа ба хөгжүүлэлтийн төсөл нь дараах тохиолдолд биет бус хөрөнгийн тодорхойлолтыг хангана:

(а) Хөрөнгийн тодорхойлолтыг хангах; ба

(б) Тодорхойлж болох, өөрөөр хэлбэл, салган тусгаарлаж болох эсвэл заавал биелүүлэх хэлцлээс (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхээс) үүссэн байх.

**Нэгдлээр (улсын секторын нэгдлээр) олж эзэмшсэн биет бус хөрөнгө**

- 39В. Хэрэв нэгдлээр олж эзэмшсэн биет бус хөрөнгө нь салган тусгаарлаж болох эсвэл заавал биелүүлэх хэлцлээс (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхээс) үүссэн бол тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих хангалттай мэдээлэл оршин байдаг. Биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан тооцооллын хувьд өөр өөр магадлал бүхий хэд хэдэн боломжит үр дүнгүүд байвал тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтэнд энэхүү тодорхой бус байдал нөлөөлнө.
- 39Г. Нэгдлээр олж эзэмшсэн биет бус хөрөнгийг гүүдвилээс салган тусгаарлаж болох боловч зөвхөн холбогдох заавал биелүүлэх хэлцэл, тодорхойлж болох хөрөнгө буюу өр төлбөрийн хамтаар салган тусгаарлах боломжтой байж болно. Ийм тохиолдолд нэгтгэгч нь биет бус хөрөнгийг гүүдвилээс тусдаа боловч холбогдох зүйлсийн хамтаар хүлээн зөвшөөрнө.
- 39Д. Бие даасан хөрөнгүүд нь төсөөтэй ашиглалтын хугацаатай бол нэгтгэгч нь харилцан бие биенийхээ гүйцээлт болох биет бус хөрөнгүүдийн бүлгийг нэг хөрөнгө мэтээр хүлээн зөвшөөрч болно. Жишээлбэл; 'брэнд' ба 'брэндийн нэр' гэсэн нэр томъёог худалдааны тэмдэг ба бусад тэмдэгтэй ихэвчлэн ижил төсөөтэй утгаар хэрэглэдэг. Гэхдээ 'брэнд' гэдэг нь худалдааны тэмдэг (буюу үйлчилгээний тэмдэг) ба түүний холбогдох худалдааны нэр, томъёолол, жор, технологийн түршлага чадвар гэх мэт харилцан бие биенийхээ гүйцээлт болох хөрөнгүүдийн бүлгийг илэрхийлэхэд нийтлэг ашиглагддаг маркетингийн ерөнхий нэр томъёо юм.

**Олж эзэмшсэн дуусаагүй судалгаа ба хөгжүүлэлтийн төслийн дараагийн тайлант үеийн зарлага**

40. **Дараах судалгаа буюу хөгжүүлэлтийн зарлагыг 52-60-р параграфын дагуу тайлагнана:**
- (а) **Тусад нь, эсвэл нэгдлээр олж эзэмшсэн бөгөөд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн, дуусаагүй судалгаа буюу хөгжүүлэлтийн төсөлд хамаарах; ба**
- (б) **Тухайн төслийг худалдан авсны дараа гарсан байх.**
41. 52-60-р параграфуудын шаардлагуудыг мөрдөнө гэдэг бол тусад нь, эсвэл нэгдлээр олж эзэмшсэн бөгөөд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн, дуусаагүй судалгаа буюу хөгжүүлэлтийн төслийн хувьд гарсан дараагийн тайлант үеийн зарлагыг дараах байдлаар тусгахыг хэлнэ. Үүнд:
- (а) Хэрэв судалгааны зарлага бол түүнийг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрөх;
- (б) Хэрэв 55-р параграфт заасан, биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй хөгжүүлэлтийн зарлага бол түүнийг гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрөх; ба

- (в) Хэрэв 55-р параграфт заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах хөгжүүлэлтийн зарлага бол түүнийг уг олж эзэмшсэн, дуусаагүй судалгаа буюу хөгжүүлэлтийн төслийн дансны үнэ дээр нэмэх.

...

## **Зардлын хүлээн зөвшөөрөлт**

66. **Биет бус хөрөнгийн зүйлд зарцуулсан зарлагыг дараахаас бусад тохиолдолд ийм зарлагыг гарсан тухай бүрт нь зардал гэж хүлээн зөвшөөрнө:**

(а) **Энэ нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах биет бус хөрөнгийн өртгийн нэг хэсгийг бүрдүүлэх (26-65-р параграфыг үзнэ үү); эсвэл**

**(б) Тухайн зүйлийг нэгдлээр олж авсан бөгөөд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй байх. Ийм тохиолдолд уг зүйл нь тухайн нэгдлийн өдрөөр гүүдвил гэж хүлээн зөвшөөрсөн дүнгийн нэг хэсгийг бүрдүүлнэ (УСНББОУС 40-ийг үзнэ үү).**

67. Зарим тохиолдолд байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүрдүүлэхийн тулд зарлагыг гаргадаг боловч хүлээн зөвшөөрч болох биет бус хөрөнгө буюу бусад хөрөнгийг олж авдаггүй эсвэл үүсгэн бий болгодоггүй. Барааны нийлүүлэлтийн хувьд байгууллага нь тухайн барааг захиран зарцуулах эрхтэй болсон үед ийм зарлагыг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Харин үйлчилгээний нийлүүлэлтийн хувьд байгууллага нь тухайн үйлчилгээг хүлээн авсан үед уг зарлагыг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; нэгдлийн нэг хэсэг байдлаар олж авснаас бусад тохиолдолд судалгааны ажлын зарлагыг түүний гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө (52-р параграфыг үзнэ үү). Гарсан үед нь зардал гэж хүлээн зөвшөөрөх зарлагын бусад жишээнд дараах зүйлс хамаарна:

(а) УСНББОУС 17-гийн дагуу үндсэн хөрөнгийн өртөгт оруулснаас бусад тохиолдолд гарааны үйл ажиллагааны зарлага (өөрөөр хэлбэл, гарааны зардал). Гарааны зардал нь хуулийн этгээдийг үүсгэн байгуулахтай холбоотойгоор гарсан хуулийн болон бичиг хэргийн зардал, шинэ байгууламж буюу үйл ажиллагааг нээх зардал (өөрөөр хэлбэл, нээлтийн өмнөх зардал), шинэ үйл ажиллагааг эхлүүлэх эсвэл шинэ бүтээгдэхүүн буюу процессыг нэвтрүүлэх зардлаас (өөрөөр хэлбэл, нээлтийн өмнөх зардал) бүрдэж болох юм;

(б) Сургалтын үйл ажиллагааны зарлага;

(в) Зар сурталчилгааны болон идэвхижүүлэлтийн үйл ажиллагааны зарлага (үүнд: захиалгын катологи болон мэдээллийн товхимолыг шуудангаар илгээх зардал хамаарна); ба

- (г) Байгууллагын бүх буюу зарим хэсгийг нүүлгэн шилжүүлэх эсвэл дахин зохион байгуулах зарлага.

...

## Ашиглалтын хугацаа

...

93А. Дараах биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тухайн эрхийг олгож буй заавал биелүүлэх хэлцлийн (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхийн) үлдсэн хугацаа байх бөгөөд тэрхүү шинэчилсэн хугацаа үүнд хамаарахгүй:

- (а) Нэгдэж буй нэг үйл ажиллагаанаас нэгдэж буй нөгөө үйл ажиллагаанд өмнө олгосон бөгөөд тэрхүү нэгдлийн үр дүн болох байгууллагын хүлээн зөвшөөрсөн лиценз буюу адилтгах эрх; эсвэл
- (б) Улсын секторын нэгдэлд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн, дахин олж эзэмшсэн эрх.

...

## Ашиглалтыг зогсоолт ба данснаас хасалт

...

114А. Дараах тохиолдолд тухайн эрхийг дараагийн тайлант үед гуравдагч талд буцаан гаргасан (борлуулсан) бол уг буцаан гаргалтын олз, гарзыг тодорхойлохдоо хэрэв байгаа бол, тэрхүү эрхийн холбогдох дансны үнийг ашиглана.

- (а) Нэгдэж буй нэг үйл ажиллагаанаас нэгдэж буй нөгөө үйл ажиллагаанд өмнө олгосон бөгөөд тэрхүү нэгдлийн үр дүн болох байгууллагын хүлээн зөвшөөрсөн лиценз буюу адилтгах эрх; эсвэл
- (б) Улсын секторын нэгдэлд биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн, дахин олж эзэмшсэн эрх.

...

## Тодруулга

### Ерөнхий зүйл

117. Байгууллага нь дотооддоо бий болгосон биет бус хөрөнгө ба бусад биет бус хөрөнгө гэдгээр ангилж, биет бус хөрөнгийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:

- (а) Ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэх, хэрэв тодорхой бол ашиглалтын хугацаа буюу ашигласан хорогдуулгын хувь хэмжээ;

...

- (д) Доорх зүйлсийг харуулсан, тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнийн тохируулга:

- (i) Нэмэгдэлт, үүнд дотоодын хөгжүүлэлтээс бий болсон, тусад нь худалдаж авсан, нэгдлээр олж авсан гэдгээр тусдаа харуулах;

...

## Хүчин төгөлдөр болох хугацаа

...

132К. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 3, 6, 18, 24, 40, 41, 66, 67, 117-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 18А, 26А, 39А-39Д, 93А, 114А параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд гүйцээх горимоор мөрдөнө. Иймээс урьд өмнөх улсын секторын нэгдлээр биет бус хөрөнгө болон гүүдвилийн хувьд хүлээн зөвшөөрсөн дүнг залруулахгүй. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 31-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

## Цар хүрээ

...

ДҮ4. НББОУС 38 нь бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн гүүдвил ба биет бус хөрөнгийн талаархи шаардлагууд болон заавар удирдамжуудыг агуулсан байдаг. Бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн гүүдвил болон биет бус хөрөнгийг энэ Стандартын цар хүрээнд хамруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУС3 нь УСНББОУС 31-ийг гаргах үедээ харгалзан үзсэн. УСНББОУС3 нь бизнесийн нэгдлийг зохицуулах УСНББОУС-ыг хараахан гаргаагүй байгаа бөгөөд улсын секторын байгууллагуудын нэгдэл хийгдсэн үед улсын секторын олон тооны тусгай асуудлууд үүсэх

магадлалтай гэж үзсэн. Бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн гүүдвил болон биет бус хөрөнгийг одоогоор энэ Стандартын цар хүрээнд хамруулан оруулах хэрэггүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-нд заасан шатлалын дагуу хэрэглэгчид нь бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн гүүдвил болон биет бус хөрөнгийг тайлагнах олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын шаардлагуудыг лавлагаа болгон харгалзана.

ДҮ4А. УСНББОУСЗ дараа нь УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийг гаргасан. УСНББОУС 40 нь улсын секторын нэгдлийн тайлагнал, үүн дотроо биет бус хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг тусгайлан тодорхойлдог. Улсын секторын нэгдлийн нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрсөн биет бус хөрөнгийн дараагийн тайлант үеийн хэмжилт ба тодруулгыг УСНББОУС 40-д заагаагүй байдаг. Иймээс улсын секторын нэгдлээр хүлээн зөвшөөрсөн гүүдвил болон биет бус хөрөнгийг энэ Стандартын цар хүрээнд оруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь дахин авч үзсэн. УСНББОУСЗ нь УСНББОУС 40-ийг гаргаж, энэ Стандартад зохих өөрчлөлтийг оруулсаны үр дүнд эдгээр хөрөнгийг энэ Стандартын цар хүрээнд хамруулан оруулах хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

## **НББОУС 38-тай харьцуулалт**

УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийг НББОУС 38, *Биет Бус Хөрөнгө*-өөс (2008 оны 12 дугаар сарын 31-нээрх) үндсэндээ бэлтгэсэн болно. УСНББОУС 31 ба НББОУС 38-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

...

- ~~НББОУС 38 нь бизнесийн нэгдлээр олж эзэмшсэн гүүдвил ба биет бус хөрөнгийн талаархи шаардлагууд болон заавар удирдамжийг агуулсан байдаг. УСНББОУС 31-д ийм заавар удирдамж байдаггүй.~~

...

## **УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

86, 129, 130, 132-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 62А-62В, 154В параграфыг шинээр нэмсэн бөгөөд 62-р параграфын дараа нэмэлт гарчиг оруулсан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.



**Шилжилтийн үед үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт  
УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх чөлөөлөх нөхцлүүд**

...

**Хөрөнгө ба/буюу өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн  
хувьд чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацаа**

...

*Бусад чөлөөлөх нөхцлүүд*

...

УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл

62А. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хөрөнгө, өр төлбөрийг гурван жилийн шилжилтийн хугацаанд хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг зөвшөөрдөг 36-р параграфын чөлөөлөх нөхцлийг мөрддөг тохиолдолд уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү чөлөөлөгдөх гурван жилийн шилжилтийн хугацааны туршид улсын секторын нэгдлийн оролцогч тал байж болох юм. Ийм чөлөөлөлт олгосон нөхцлүүдийн хугацаа дуусах ба/буюу холбогдох хөрөнгө, өр төлбөрийг зохих УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжих (аль түрүүнд болох өдөр) хүртэл уг анх удаа мөрдөж буй байгууллага нь нь тэрхүү улсын секторын нэгдэлтэй холбоотой хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх ба/буюу хэмжих шаардлагагүй юм.

62Б. Анх удаа мөрдөж буй байгууллага нь дээрх 62А параграфт дурдсан чөлөөлөх нөхцлийг мөрддөг тохиолдолд улсын секторын нэгдэлтэй холбоотойгоор гүүдвилийг хүлээн зөвшөөрөхгүй. Анх удаа мөрдөж буй байгууллага нь доорх (а) ба (б) заалтад дурдсан дүнгүүдийн хоорондох зөрүүг цэвэр хөрөнгө/ өмчид хүлээн зөвшөөрнө:

(а) Дараах дүнгүүдийн нийлбэр:

- (i) Шилжүүлсэн аливаа төлбөр;
- (ii) Худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоо;
- (iii) Худалдан авсан үйл ажиллагааны хувьд өмнө нь эзэмшиж байсан аливаа өмчийн хувь оролцоо.

(б) Олж эзэмшсэн аливаа тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн цэвэр дүн.

62В. УСНББОУС 40-ийг гүйцээх горимоор мөрдөнө. Иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 40-ийг мөрдөхөөс өмнө хийгдсэн улсын

секторын нэгдлийн үр дүнд хүлээн зөвшөөрсөн гүүдвилийн аливаа дүнг залруулахгүй.

**Мөрдөх хугацаанд үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй чөлөөлөх нөхцлүүд**

...

УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө

86. Гадаад үйл ажиллагааг худалдан авснаас үүссэн аливаа гүүдвил болон тухайн гадаад үйл ажиллагааны худалдан авалтаар үүссэн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд хийгдэх аливаа бодит үнэ цэнийн тохируулгыг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь тэрхүү гадаад үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөртэй адилаар УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс эхлэн гүйцээх горимоор тайлагнах шаардлагыг даган мөрдөнө (~~байгууллагын нэгдлийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний хөлбөгдөж стандартыг~~ УСНББОУС 40-ийг үзнэ үү).

...

**УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан, УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан, УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт**

129. Хөрөнгө оруулалтын байгууллагын хяналтанд буй байгууллага байхаас бусад тохиолдолд уг хяналтанд буй байгууллага нь хяналт тавигч байгууллагаасаа хожуу анх удаа мөрдөж буй байгууллага болсон бол тэрхүү хяналтанд буй байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө дараах дүнгийн аль нэгээр өөрийн санхүүгийн тайландаа хэмжинэ:
- (а) Хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд буй байгууллагыг олж эзэмшсэн ~~байгууллагын нэгдлийн~~ үлсын секторын нэгдлийн үр нөлөө ба нэгтгэлийн горимын хувьд тохируулга хийгээгүй бол тухайн хяналтанд буй байгууллагын УСНББОУС-ыг мөрдсөн өдөрт үндэслэн энэ УСНББОУС-ын дагуу тодорхойлсон ба хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдах дансны үнэ; эсвэл

...

130. Харин хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагаасаа (хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрээс) хожуу, анх удаа мөрдөж буй байгууллага болсон бол уг хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагын (хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн) хөрөнгө, өр төлбөрийг түүний (хараат

байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн) санхүүгийн тайланд тусгаж байсантай ижил дансны үнээр өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хэмжиж, тусгана. Гэхдээ энэ УСНББОУС-ын хүрээнд мөрдөж болох чөлөөлөлтийн нөхцлүүдийг харгалзан, нэгтгэлийн тохируулга, өмчийн аргын нягтлан бодох бүртгэлийн тохируулга, түүнчлэн хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд буй байгууллагыг (хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийг) олж эзэмшсэн байгууллагын нэгдлийн улсын секторын нэгдлийн үр нөлөөний хувьд тохируулга хийсний дараах дүнгээр хэмжинэ. Үүнтэй адилаар, хяналтанд буй байгууллага нь өөрийн тусдаа санхүүгийн тайлангийн хувьд нэгтгэсэн санхүүгийн тайлангаас эрт эсвэл хожуу, анх удаа мөрдөж буй байгууллага болсон бол тус хяналтанд буй байгууллага нь энэ УСНББОУС-д мөрдөж болох нэгтгэлийн тохируулгаас бусад чөлөөлөх нөхцлүүдийг харгалзан өөрийн хөрөнгө, өр төлбөрийг эдгээр санхүүгийн тайлангийн аль алинд ижил дүнгээр хэмжинэ.

...

### УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр

132. Анх удаа мөрдөж буй байгууллага нь хамтарсан үйлдвэрт оруулсан өөрийн хөрөнгө оруулалтыг хувь тэнцүүлэн нэгтгэх аргыг ашиглан нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг өмнө нь хувь тэнцүүлэн нэгтгэсэн байгууллагын хөрөнгө, өр төлбөрийн үүн дотроо, худалдан авалтын ажил гүйлгээнээс үүссэн, худалдан авсан аливаа гүүдвэлийн нийт дансны үнээр хэмжинэ (~~байгууллагын нэгдлийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний хөлбөгдөх стандартыг УСНББОУС 40-ийг үзнэ үү~~).

...

### Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 154В. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 86, 129, 130, 132-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 62А-62В параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## **Дүгнэлтийн үндэслэл**

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

**Үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлдөг чөлөөлөх нөхцлүүд**

...

### УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл

ДҮ79А. УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь улсын секторын нэгдэлтэй холбоотой бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрөх шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл олгох эсэхийг авч үзсэн. УСНББОУС 40-ийг гүйцээх горимоор мөрддөг, иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь уг Стандартыг мөрдөхөөс өмнө гарч тохиолдсон улсын секторын нэгдлийн хувьд өөрийн нягтлан бодох бүртгэлд залруулга хийх шаардлагагүй гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Гэвч анх удаа мөрдөж буй байгууллагын гурван жилийн шилжилтийн хугацаанд улсын секторын нэгдэл хийгдэж болох юм. Ижил төсөөтэй бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, хэмжихийг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаардахгүй, харин улсын секторын нэгдэлтэй холбоотой бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, хэмжихийг түүнээс зөвхөн шаардах нь тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллийг бүрдүүлэхгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ79Б. Иймээс, УСНББОУСЗ нь улсын секторын нэгдэлтэй холбоотой бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй ба/буюу хэмжихгүй байхыг анх удаа мөрдөж буй байгууллагад зөвшөөрөх шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлийг энэхүү Стандартын нэг хэсэг байдлаар олгохыг зөвшөөрсөн. Анх удаа мөрдөж буй байгууллага нь улсын секторын нэгдэлтэй холбоотой бүх хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, хэмждэггүй тохиолдолд гүүдвлиийг хүлээн зөвшөөрөх хэрэггүй гэдгийг УСНББОУСЗ нь бас хүлээн зөвшөөрсөн.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

## УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан

ХЗУ82. Хэрэв анх удаа мөрдөж буй байгууллага нь хяналтанд буй байгууллагыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу нэгтгэдэггүй байсан бол тус байгууллага нь хяналтанд буй байгууллагын хөрөнгө, өр төлбөрийг УСНББОУС-ыг мөрдсөний дараах, түүний аккруэл суурьт санхүүгийн тайланд тусгаж байсантай ижил дансны үнээр өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хэмжиж, тусгана. Гэхдээ нэгтгэлийн тохируулга болон уг хяналтанд буй байгууллагыг олж эзэмшсэн байгууллагын нэгдлийн улсын секторын нэгдлийн үр нөлөөний хувьд тохируулга хийсний дараах дүнгээр хэмжинэ (УСНББОУС 33-ын 130-р параграф). Хэрэв хяналтанд буй байгууллага нь өөрийн санхүүгийн тайландаа аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрддөггүй байсан бол өмнөх өгүүлбэрт дурдсан дансны үнэ нь түүний санхүүгийн тайлангийн хувьд УСНББОУС-аар шаардах байсан тийм дүн байна.

## УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан-д оруулсан нэмэлт өөрчлөлт

4, 40, 52, 56, 57, 63-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 55А, 79В, 79Г параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### Цар хүрээ

...

### Улсын секторын нэгдэл

4. Энэ Стандарт нь улсын секторын нэгдлийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд ба нэгдэлд тэдгээрийн үзүүлэх үр нөлөө, үүн дотроо улсын секторын нэгдлээс бий болсон гүүдвилийг авч үздэггүй (~~улсын секторын нэгдлийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний хөлбөгдөх стандартыг УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийг~~ үзнэ үү).

...

### Нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд

...

### Нэгтгэлийн горим

40. Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь:

...

- (б) Хяналтанд буй байгууллага бүр дэх хяналт тавигч байгууллагын хөрөнгө оруулалтын дансны үнэ болон хяналтанд буй байгууллага бүрийн цэвэр хөрөнгө/өмч дэх уг хяналт тавигч байгууллагын хувь оролцоог харилцан суутгана (устгана) (аливаа холбогдох гүүдвилийг хэрхэн тайлагнахыг нягтлан бодох бүртгэлийн өлөн улсын буюу үндэсний холбогдох стандартад УСНББОУС 40-д тайлбарласан).

...

## Хяналтаа алдах

52. Хэрэв хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь хяналтаа алдвал уг хяналт тавигч байгууллага нь:

- (а) Өмнө нь хяналтанд байсан байгууллагын хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаас хасаж, үл хүлээн зөвшөөрнө;
- (б) Хяналтаа алдах үед өмнө нь хяналтанд байсан уг байгууллагад хадгалан үлдсэн аливаа хөрөнгө оруулалтыг түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрч, түүнийг болон тухайн хяналтанд байсан байгууллагаас авах эсвэл түүнд төлөх дүнг холбогдох УСНББОУС-уудын дагуу дараагийн тайлант үед тайлагнана. Тэрхүү бодит үнэ цэнээрх үлдсэн хувь оролцоог 54(б)(iii) ба 55А параграфт заасны дагуу дахин хэмжинэ. Хяналтаа алдсан өдрөөр уг дахин хэмжсэн үнэ цэнийг УСНББОУС 29-ийн дагуу санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ, хэрэв хамааралтай бол тухайн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрөх үеийн өртөг гэж үзнэ.
- (в) Өмнөх хяналтын хувь оролцоонд хамаарах хяналтаа алдсантай холбоотой олз, гарзыг 54-55А параграфт тусгайлан заасны дагуу хүлээн зөвшөөрнө.

...

55А. Өмчийн арга ашиглан тайлагнадаг хараат байууллага буюу хамтарсан үйлдвэртэй холбоотой ажил гүйлгээний үр дүнд хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг өөртөө агуулаагүй тийм хяналтанд буй байгууллагын хяналтаа алдсан бол тухайн хяналт тавигч байгууллага нь уг олз, гарзыг 54-55-р параграфын дагуу тодорхойлно. Уг ажил гүйлгээнээс үүссэн олз, гарзыг тэрхүү хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх зөвхөн харилцан холбоогүй хөрөнгө оруулагчдын хувь оролцооны хэмжээгээр тухайн хяналт тавигч байгууллагын ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Олзын үлдсэн хэсгийг тэрхүү хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж, устгана. Түүнчлэн, хэрэв хяналт тавигч байгууллага өмнө нь хяналтанд байсан байгууллагадаа хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг хадгалж үлдсэн бөгөөд уг хяналтанд

байсан байгууллага нь одоо өмчийн арга ашиглан тайлагнах хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр болсон бол тухайн хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүссэн олз, гарзын хэсгийг тэрхүү шинэ хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх зөвхөн харилцан холбоогүй хөрөнгө оруулагчдын хувь оролцооны хэмжээгээр өөрийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Олзын үлдсэн хэсгийг уг өмнө нь хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж, устгана. Хэрэв хяналт тавигч байгууллага нь одоо УСНББОУС 29-ийн дагуу тайлагнах уг өмнө нь хяналтанд байсан байгууллагадаа хөрөнгө оруулалтын зарим хэсгийг хадгалж үлдсэн бол тэрхүү хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүссэн олз, гарзын хэсгийг тухайн хяналт тавигч байгууллагын ашиг, алдагдалд бүтэн дүнгээр нь хүлээн зөвшөөрнө.

### **Хөрөнгө оруулалтын байгууллага: Бодит үнэ цэнийн шаардлага**

56. 57-р параграфт зааснаас бусад тохиолдолд, хөрөнгө оруулалтын байгууллага нь өөр байгууллагын хяналтыг олж авах үедээ өөрийн хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэхгүй буюу УСНББОУС 40-ийг мөрдөхгүй. Харин үүний оронд, хөрөнгө оруулалтын байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтаа УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжинэ.
57. Хэрэв хөрөнгө оруулалтын байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага биш хяналтанд буй байгууллагатай бөгөөд түүний үндсэн зорилго, үйл ажиллагаа нь тухайн хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай (МЗУ98-МЗУ100-р параграфыг үзнэ үү) холбоотойгоор үйлчилгээ үзүүлэх явдал бол уг хөрөнгө оруулалтын байгууллага нь 56-р параграфын шаардлагыг үл харгалзан тэрхүү хяналтанд буй байгууллагыг энэ Стандартын 38-55-р параграфын дагуу нэгтгэх бөгөөд ийм аливаа хяналтанд буй байгууллагын худалдан авалтын хувьд УСНББОУС 40-ийн шаардлагуудыг дагаж мөрдөнө.

...

### **Хөрөнгө оруулалтын байгууллагын статусын өөрчлөлтийг тайлагнах**

63. Байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага байхаа больсон тохиолдолд тухайн байгууллага нь 56-р параграфын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр өмнө нь хэмжиж байсан аливаа хяналтанд буй байгууллагын хувьд улсын секторын нэгдлийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартыг УСНББОУС 40-ийг дагаж мөрдөнө. Ийм статусын өөрчлөлтийн өдөр нь төсөөлөн тооцсон худалдан авалтын өдөр байна. Төсөөлөн тооцсон худалдан авалтаас үүссэн

тохиролцоот худалдан авалтын аливаа гүүдвил буюу олзыг хэмжих тохиолдолд уг төсөөлөн тооцсон худалдан авалтын өдрөөрх хяналтанд буй байгууллагын бодит үнэ цэнэ нь тэрхүү шилжүүлсэн, төсөөлөн тооцсон төлбөрийг илэрхийлнэ. Статус өөрчлөгдсөн өдрөөс эхлэн бүх хяналтанд буй байгууллагуудыг энэ Стандартын 38-51-р параграфын дагуу нэгтгэнэ.

...

## Хүчин төгөлдөр болох хугацаа

...

79В. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 4, 40, 56, 57, 63-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

79Г. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 52-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 55А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС3-өөс тодорхойлсон өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд гүйцээх горимоор мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дурдсан өдрөөс өмнө мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд хэрэв хараахан мөрдөөгүй байгаа бол тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 35-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

**Хөрөнгө оруулагч ба түүний хараат байгууллага, хамтарсан үйлдвэрийн хоорондох хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлт**

...

ДҮ56. СТ 60, Улсын Секторын Нэгдэл-ийг боловсруулж байх үедээ УСНББОУС3 нь хяналтанд өмнө байсан байгууллагын хяналтаа



алдалтыг хөрөнгө оруулагчийн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр болгон хэрхэн тайлагнах талаархи заавар удирдамжийг тусган оруулах эсэхийг дахин харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь НББОУСЗ-өөс гаргасан *Хөрөнгө Оруулагч ба түүний Хараат Компани эсвэл Хамтарсан Үйлдвэрийн Хоорондох Хөрөнгийн Борлуулалт буюу Хөрөнгөөрх Хувь Нийлүүлэлт* (СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)-д тусгасан заавар удирдамжийг нягталж үзсэн. Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани буюу хамтарсан үйлдвэрийн хоорондох ажил гүйлгээний хэсэгчилсэн олз, гарз болох байсан үг НББОУСЗ-ийн нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэв УСНББОУС 35-д оруулан мөрдвөл түүний үр нөлөөг үйл ажиллагааг агуулдаггүй тэрхүү өмнө нь хяналтанд байсан байгууллагын хяналтыг алдсанаас үүсэх олз, гарзад зөвхөн хамааруулан мөрдөнө. УСНББОУСЗ нь НББОУСЗ-ийн арга хандлагаас гажих, улсын секторын ямар нэг тусгай учир шалтгааныг тогтоогоогүй. Иймээс УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамжийг (СТ 60 дахь нэр томъёо ба тодорхойлолттой нийцүүлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулсан) УСНББОУС 35-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

ДҮ57. 2015 оны 12 дугаар сард НББОУСЗ нь *Хөрөнгө Оруулагч ба түүний Хараат Компани эсвэл Хамтарсан Үйлдвэрийн Хоорондох Хөрөнгийн Борлуулалт буюу Хөрөнгөөрх Хувь Нийлүүлэлт* (СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)-д тусгасан заавар удирдамжийн хэрэгжилтийг хойшлуулсан. Яагаад гэвэл, НББОУСЗ нь өмчийн нягтлан бодох бүртгэлийн талаархи өөрийн төслийн нэг хэсэг болгон энэхүү талбарт цаашдын судалгаа хийж байсан бөгөөд богино хугацааны дотор өөрсдийн нягтлан бодох бүртгэлд хоёр удаа өөрчлөлт оруулахыг аж ахуйн нэгжүүдээс шаардахыг хүсээгүй. Хүчин төгөлдөр болох хугацааг хойшлуулахдаа НББОУСЗ нь илүү сайн санхүүгийн тайлагналын мөрдөлтөнд саад учруулахыг хүсээгүй тул уг заавар удирдамжийн дурдсан хугацаанаас өмнө мөрдөлтийг зөвшөөрсөн хэвээр байсан. УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамжийн хэрэгжилтийг хойшлуулах НББОУСЗ-ийн шийдвэрийг нягталж үзсэн. УСНББОУСЗ нь НББОУСЗ-ийн арга хандлагаас гажих, улсын секторын ямар нэг тусгай учир шалтгааныг тогтоогоогүй. Иймээс УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамжийг УСНББОУС 35-д тусган оруулж, УСНББОУСЗ-өөс тодорхойлсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг зөвшөөрсөн.

## **Үлгэрчилсэн жишээ**

*Эдгээр жишээ нь УСНББОУС 35-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

*Нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд: хяналтаа алдах (52-55А параграф)*

ҮЖ13А. Өөртөө үйл ажиллагаа агуулаагүй, хяналтанд буй байгууллага дахь хувь оролцооны борлуулалтын арга хандлагыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

#### **Жишээ 44А**

Хяналт тавигч байгууллага нь өөртөө үйл ажиллагаа агуулаагүй, хяналтанд буй байгууллага дахь хувь оролцоог 100 хувь эзэмшдэг. Тус хяналт тавигч байгууллага нь өөрөө 20 хувийн оролцоотой байдаг хараат байгууллагадаа уг хяналтанд буй байгууллага дахь өөрийн хувь оролцооны 70 хувийг борлуулсан. Энэ ажил гүйлгээний үр дүнд тус хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд буй байгууллага дахь хяналтаа алдсан. Хяналтанд буй байгууллагын цэвэр хөрөнгийн дансны үнэ нь 100ТН ба борлуулсан хувь оролцооны дансны үнэ нь 70ТН ( $70ТН = 100ТН \times 70\%$ ) байна. Борлуулалтаас хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнэ нь 210ТН ба энэ нь мөн уг борлуулсан хувь оролцооны бодит үнэ цэнэ юм. Өмнө нь хяналтанд байсан энэхүү байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалт нь өмчийн арга ашиглан тайлагнах хараат байгууллага болох бөгөөд түүний бодит үнэ цэнэ нь 90ТН байна. 55А параграфтаар шаардсан үстгалтыг хийхийн өмнө 54-55-р параграфын дагуу тодорхойлсон олз нь 200ТН ( $200ТН = 210ТН + 90ТН - 100ТН$ ) байна. Энэхүү олз нь дараах хоёр хэсгээс бүрдэнэ:

- (а) Хяналтанд буй байгууллагын 70 хувийн хувь оролцоог хараат байгууллагад борлуулснаас үүссэн олз (140ТН). Энэ олз нь хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнэ (210ТН) ба борлуулсан хувь оролцооны дансны үнийн (70ТН) хоорондох зөрүү юм. 55А параграфын дагуу тус хяналт тавигч байгууллага нь уг одоо байгаа хараат байгууллага дахь харилцан холбоогүй хөрөнгө оруулагчдын хувь оролцоонд хамаарах олзын дүнг өөрийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Энэ нь уг олзын 80 хувь буюу 112ТН ( $112ТН = 140ТН \times 80\%$ ) байна. Олзын үлдсэн 20 хувийг ( $28ТН = 140ТН \times 20\%$ ) одоо байгаа хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж, устгана.
- (б) Өмнө нь хяналтанд байсан байгууллагад шууд хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүссэн олз (60ТН). Энэ олз нь үүний өмнө хяналтанд байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ (90ТН) ба тэрхүү хяналтанд байсан байгууллагын цэвэр хөрөнгийн дансны үнэ ( $30ТН = 100ТН \times 30\%$ ) хоорондох зөрүү юм. Хяналт тавигч байгууллага нь уг шинэ хараат байгууллага дахь харилцан холбоогүй хөрөнгө оруулагчдын хувь оролцоонд хамаарах олзын дүнг 55А параграфын дагуу өөрийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Энэ нь уг олзын 56 хувь ( $70ТН \times 80\%$ ) буюу 34ТН ( $34ТН = 60ТН \times 56\%$ ) байна. Олзын үлдсэн 44 хувь буюу 26ТН ( $26ТН = 60ТН \times 44\%$ )-ийг уг өмнө нь хяналтанд

байсан байгууллагад хадгалж үлдсэн хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж, устгана.

## **УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт-д оруулсан нэмэлт өөрчлөлт**

26, 31, 33-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 34А, 34Б, 51Б, 51В параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

### **Өмчийн аргын хэрэглээ**

...

### **Өмчийн арга хэрэглэхийг зогсоох**

26. Байгууллагын хөрөнгө оруулалт нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр байхаа больсон өдрөөс эхлэн тухайн байгууллага нь өмчийн арга хэрэглэхийг дараах байдлаар зогсооно:

- (а) Хэрэв хөрөнгө оруулалт нь хяналтанд буй байгууллага болсон бол тухайн байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтыг улсын секторын нэгдлийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн өлөн улсын буюу үндэсний хөлбөгдөх стандарт-УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл ба УСНББОУС 35-ын дагуу тайлагнана.

...

### **Өмчийн аргыг хэрэглэх горимууд**

...

31. Байгууллага (үүнд түүний нэгтгэсэн, хяналтанд буй байгууллагууд хамаарна) болон түүний хараат байгууллага, эсвэл хамтарсан үйлдвэрийн хооронд гарсан бөгөөд УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэхгүй хөрөнгүүдтэй холбоотой “дээш чиглэсэн” ба “доош чиглэсэн” ажил гүйлгээний олз, гарзыг уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн хувьд холбоогүй тал болох зөвхөн тэдгээр хөрөнгө оруулагчдын хувь оролцооны хэмжээгээр тухайн байгууллагын санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө. “Дээш чиглэсэн” ажил гүйлгээ нь тухайлбал, хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэрээс хөрөнгийг тухайн хөрөнгө оруулагчид борлуулах ажил гүйлгээ юм. Ийм ажил гүйлгээнээс үүссэн, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн олз,

гарзын хувьд тухайн байгууллагын эзлэх хувь хэмжээг устган цэвэрлэдэг. “Доош чиглэсэн” ажил гүйлгээ нь тухайлбал, хөрөнгө оруулагчаас өөрийн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт хөрөнгө борлуулах ажил гүйлгээ юм. Ийм ажил гүйлгээнээс үүссэн, хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн олз, гарз дахь уг хөрөнгө оруулагчийн хувь оролцоог устгаж цэвэрлэнэ.

...

33. Хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт өмчийн хувь оролцоотой болсны хариуд тэдгээр хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрт өгсөн, гэхдээ УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэхгүй, мөнгөн зүйлсийн бус хөрөнгөөрх хувь нийлүүлэлт нь УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө-д заасан нөхцлүүдийн дагуу арилжааны шинж чанарыг агуулаагүй байхаас бусад тохиолдолд уг хувь нийлүүлэлтээс үүссэн олз, гарзыг 31-р параграфын дагуу тайлагнана. Хэрэв ийм хувь нийлүүлэлт нь арилжааны шинж чанарыг агуулаагүй бол олз, гарзыг хэрэгжээгүй гэж үзэх бөгөөд 34-р параграфыг бас мөрдөхөөс бусад тохиолдолд уг олз, гарзыг хүлээн зөвшөөрөхгүй. Ийм хэрэгжээгүй олз, гарзыг өмчийн арга ашиглан тайлагнасан хөрөнгө оруулалтаас хасаж, устгах бөгөөд хөрөнгө оруулалтаа өмчийн арга ашиглан тайлагнадаг байгууллагын нэгтгэсэн буюу тусдаа санхүүгийн байдлын тайланд хойшлогдсон олз, гарз байдлаар толилуулахгүй.

...

- 34А. Байгууллага (үүнд түүний нэгтгэсэн, хяналтанд буй байгууллагууд хамаарна) болон түүний хараат байгууллага, эсвэл хамтарсан үйлдвэрийн хооронд гарсан бөгөөд УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэхгүй хөрөнгүүдтэй холбоотой “доош чиглэсэн” ажил гүйлгээний олз, гарзыг уг хөрөнгө оруулагчийн санхүүгийн тайланд бүхэлд нь хүлээн зөвшөөрнө.

- 34Б. Байгууллага нь хоёр буюу хэд хэдэн хэлцлээр (ажил гүйлгээгээр) хөрөнгөө борлуулж эсвэл хувь нийлүүлж болох юм. Борлуулсан эсвэл хувь нийлүүлсэн хөрөнгө нь УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэх эсэхийг тогтоохдоо байгууллага нь тэдгээр хөрөнгийн борлуулалт буюу хувь нийлүүлэлт нь УСНББОУС 35-ын 53-р параграфын шаардлагуудын дагуу нэг ажил гүйлгээ байдлаар тайлагнавал зохих олон хэлцлийн нэг хэсэг мөн эсэхийг харгалзан үзнэ.

...

## **Хүчин төгөлдөр болох хугацаа**

...

- 51Б. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 26-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-

нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

51В. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 31, 33-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 34А, 34Б параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС3-өөс тодорхойлсон өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд гүйцээх горимоор мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дурдсан өдрөөс өмнө мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд хэрэв хараахан мөрдөөгүй байгаа бол тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## Дүгнэлтийн үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 36-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

**Хөрөнгө оруулагч ба түүний хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэрийн хоорондох хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлт**

...

ДҮ14. СТ 60. Улсын Секторын Нэгдэл-ийг боловсруулж байх үедээ УСНББОУС3 нь хөрөнгө оруулагч ба түүний хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэрийн хоорондох хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлтийг хэрхэн тайлагнах талаархи заавар удирдамжийг тусган оруулах эсэхийг дахин харгалзан үзсэн. УСНББОУС3 нь НББОУС3-өөс гаргасан Хөрөнгө Оруулагч ба түүний Хараат Компани эсвэл Хамтарсан Үйлдвэрийн Хоорондох Хөрөнгийн Борлуулалт буюу Хөрөнгөөрх Хувь Нийлүүлэлт (СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)-д тусгасан заавар удирдамжийг нягталж үзсэн. Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани буюу хамтарсан үйлдвэрийн хоорондох ажил гүйлгээний хэсэгчилсэн олз, гарз болох байсан уг НББОУС3-ийн нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэв УСНББОУС 36-д оруулан мөрдвөл түүний үр нөлөөг үйл ажиллагааг агуулдаггүй тэрхүү хөрөнгийн борлуулалт буюу хөрөнгөөрх хувь нийлүүлэлтээс үүсэх олз, гарзад зөвхөн хамааруулан мөрдөнө. УСНББОУС3 нь НББОУС3-ийн

арга хандлагаас гажих, улсын секторын ямар нэг тусгай учир шалтгааныг тогтоогоогүй. Иймээс УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамжийг (СТ 60 дахь нэр томъёо ба тодорхойлолттой нийцүүлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулсан) УСНББОУС 36-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

ДҮ15. 2015 оны 12 дугаар сард НББОУСЗ нь Хөрөнгө Оруулагч ба түүний Хараат Компани эсвэл Хамтарсан Үйлдвэрийн Хоорондох Хөрөнгийн Борлуулалт буюу Хөрөнгөөрх Хувь Нийлүүлэлт (СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан Нэмэлт өөрчлөлтүүд)-д тусгасан заавар удирдамжийн хэрэгжилтийг хойшлуулсан. Яагаад гэвэл, НББОУСЗ нь өмчийн нягтлан бодох бүртгэлийн талаархи өөрийн төслийн нэг хэсэг болгон энэхүү талбарт цаашдын судалгаа хийж байсан бөгөөд богино хугацааны дотор өөрсдийн нягтлан бодох бүртгэлд хоёр удаа өөрчлөлт оруулахыг аж ахуйн нэгжүүдээс шаардахыг хүсээгүй. Хүчин төгөлдөр болох хугацааг хойшлуулахдаа НББОУСЗ нь илүү сайн санхүүгийн тайлагналын мөрдөлтөнд саад учруулахыг хүсээгүй тул уг заавар удирдамжийн дурдсан хугацаанаас өмнө мөрдөлтийг зөвшөөрсөн хэвээр байсан. УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамжийн хэрэгжилтийг хойшлуулах НББОУСЗ-ийн шийдвэрийг нягталж үзсэн. УСНББОУСЗ нь НББОУСЗ-ийн арга хандлагаас гажих, улсын секторын ямар нэг тусгай учир шалтгааныг тогтоогоогүй. Иймээс УСНББОУСЗ нь энэхүү заавар удирдамжийг (УСНББОУС 40 дэх нэр томъёо ба тодорхойлолттой нийцүүлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулсан) УСНББОУС 36-д тусган оруулж, УСНББОУСЗ-өөс тодорхойлсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг зөвшөөрсөн.

## **УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр-т оруулсан нэмэлт өөрчлөлт**

32-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 24А, 41А, 42Б, 42В, МЗУ33А-МЗУ33Г параграфыг шинээр нэмсэн. 23-р параграфын өмнөх гарчгийг өөрчилж, 41А, МЗУ33А параграфын өмнө гарчгийг нэмж оруулсан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

## **Хамтын хэлэлцээрийн оролцогч талуудын санхүүгийн тайлан (МЗУ34 МЗУ33А-МЗУ37-р параграфыг үзнэ үү)**

### **Хамтын үйл ажиллагаа**

...

24А. Байгууллага нь хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшсэн бөгөөд тэрхүү хамтын үйл ажиллагаа нь УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-д тодорхойлсон, үйл ажиллагааг

бүрдүүлэх үйл ажиллагаа байх тохиолдолд 23-р параграфт дурдсанчлан, өөрийн хувь оролцоонд хамаарах хэмжээгээр тухайн байгууллага нь энэ Стандарт дахь заавар удирдамжтай үл зөрчилдөх, УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-д заасан худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн бүх зарчмуудыг даган мөрдөх бөгөөд худалдан авалттай холбоотойгоор тэдгээр УСНББОУС-уудад шаардсан мэдээллийг тодруулна. Хамтын үйл ажиллагаагаар эрхлэх үйл ажиллагаа нь үйл ажиллагааг бүрдүүлэх тийм хамтын үйл ажиллагаан дахь анхны болон нэмэлт хувь оролцооны аль алины худалдан авалтанд энэхүү заалт хамаарна. Ийм хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны тайлагналыг МЗУЗ3А-МЗУЗ3Г параграфт тусгайлан заасан.

...

## Шилжилтийн нөхцөл

...

**Хамтарсан үйлдвэр – Хувь тэнцүүлэн нэгтгэх аргаас өмчийн аргад шилжих**

...

32. Хувь тэнцүүлэн нэгтгэх аргаас өмчийн аргад шилжих тохиолдолд байгууллага нь тухайн хамтарсан үйлдвэрт оруулсан өөрийн хөрөнгө оруулалтыг тэрхүү шилжилтийн яг өмнөх тайлант үеийн эхэн дэх байдлаар хүлээн зөвшөөрнө. Тухайн байгууллагын хувь тэнцүүлэн өмнө нь нэгтгэсэн хөрөнгө, өр төлбөрийн, үүн дотроо худалдан авалтын ажил гүйлгээнээс үүссэн аливаа гүүдвилийн дансны үнийн нийт дүнгээр уг анхны хөрөнгө оруулалтыг хэмждэг (байгууллагын нэгдлийг тайлагнах болон хамтарсан үйлдвэрүүдэд гүүдвилийг хуваарилах талаархи заавар удирдамжийг байгууллагын нэгдэл ба хамтын хэлэлцээрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний хөлбөгдөх стандартаас үзэж болно). Хэрэв гүүдвил нь мөнгө бий болгогч арай том нэгж буюу нэгжүүдийн бүлэгт өмнө нь хамаарч байсан бол байгууллага нь тэрхүү гүүдвил харъяалагдаж байсан мөнгө бий болгогч нэгж буюу нэгжүүдийн бүлэг болон тухайн хамтарсан үйлдвэрийн тус тусын харгалзах дансны үнэд үндэслэн уг гүүдвилийг хамтарсан үйлдвэрт хуваарилна.

...

**Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын тайлагнал**

41А. 2017 оны 01 дүгээр сард гаргасан, УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 24А, 42Б, МЗУЗ3А-МЗУЗ3Г параграфуудыг шинээр

нэмсэн. Байгууллага нь УСНББОУС 40-д тодорхойлсон, үйл ажиллагааг бүрдүүлэх үйл ажиллагаа бүхий хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалт, түүнчлэн эдгээр нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн анхны тайлант үеийн эхлэлээс хойш гарч тохиолдсон ийм худалдан авалтын хувьд эдгээр нэмэлт өөрчлөлтийг гүйцээх горимоор мөрдөнө. Иймээс өмнөх тайлант үеүдэд гарч тохиолдсон, хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын хувьд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг залруулахгүй.

## Хүчин төгөлдөр болох хугацаа

...

42Б. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 24А, 41А, МЗУЗ3А-МЗУЗ3Г параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

42В. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 32-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

## Мөрдөх заавар удирдамж

*Энэ Хавсралт нь УСНББОУС 37-гийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

...

## Хамтын хэлэлцээрийн оролцогч талуудын санхүүгийн тайлан (23-28-р параграф)

### Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын тайлагнал

МЗУЗ3А. Байгууллага нь хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшсэн бөгөөд тэрхүү хамтын үйл ажиллагаа нь УСНББОУС 40-д тодорхойлсон, үйл ажиллагааг бүрдүүлэх тийм үйл ажиллагаа байх тохиолдолд 23-р параграфт дурдсанчлан, өөрийн хувь оролцоонд



хамаарах хэмжээгээр тухайн байгууллага нь энэ Стандарт дахь заавар удирдамжтай үл зөрчилдөх, УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-д заасан худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн бүх зарчмуудыг даган мөрдөх бөгөөд худалдан авалттай холбоотойгоор тэдгээр УСНББОУС-уудад шаардсан мэдээллийг тодруулна. Энэ Стандарт дахь заавар удирдамжтай үл зөрчилдөх, худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн зарчмуудад дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Гажих нөхцлүүдийг нь УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-д зааснаас бусад, тодорхойлогдох хөрөнгө ба өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжих;
- (б) Өрийн буюу өмчийн үнэт цаас гаргах зардлыг УСНББОУС 28 ба УСНББОУС 29-ийн дагуу хүлээн зөвшөөрдөг гажих тохиолдлоос бусад, худалдан авалттай холбоотой өртөг зардлыг тухайн өртөг зардал гарсан ба үйлчилгээг хүлээн авсан тайлант үеүдэд зардлаар хүлээн зөвшөөрөх;
- (в) Олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн тухайн худалдан авалтын өдрөөрх цэвэр дүнгээс илүү шилжүүлсэн төлбөр хэрэв байгаа бол уг илүү давсан дүнг гүүдвил гэж хүлээн зөвшөөрөх; ба
- (г) Гүүдвилйг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг хамгийн наад зах нь жил бүр сорьж шалгах ба худалдан авалтаар олж эзэмшсэн гүүдвилйин хувьд УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-аар шаардсанчлан, тухайн мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ буурсан шинж тэмдэг байгаа эсэхийг сорьж шалгах.

МЗУ33Б. Хамтын үйл ажиллагаанд оролцож буй талуудын нэг нь хамтын үйл ажиллагааг үүсгэн бүрдүүлэх үедээ УСНББОУС 40-д тодорхойлсны дагуу одоо оршин буй үйл ажиллагаагаар уг хамтын үйл ажиллагаанд хувь нийлүүлсэн бол, зөвхөн тийм тохиолдолд тэрхүү хамтын үйл ажиллагааны үүсгэн бүрдүүлэлтэнд 24А болон МЗУ33А параграфуудыг бас мөрдөнө. Гэвч хамтын үйл ажиллагаанд оролцож буй бүх талууд нь хамтын үйл ажиллагааг үүсгэн бүрдүүлэх үедээ үйл ажиллагаа биш, тийм хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгээр хамтын үйл ажиллагаанд хувь нийлүүлсэн зөвхөн тэр тохиолдолд уг хамтын үйл ажиллагааны үүсгэн бүрдүүлэлтэнд эдгээр параграфуудыг мөрдөхгүй.

МЗУ33В. Хамтын үйл ажиллагаа эрхлэгч нь УСНББОУС 40-д тодорхойлсны дагуу үйл ажиллагааг бүрдүүлэх хамтын үйл ажиллагаанд нэмэлт хувь оролцоог олж эзэмшснээр тэрхүү хамтын үйл ажиллагаанд дахь өөрийн хувь оролцоог нэмэгдүүлж болно. Энэ тохиолдолд хэрэв хамтын үйл ажиллагаа эрхлэгч нь хамтын хяналтаа хадгалан үлдэх бол уг хамтын үйл ажиллагаанд өмнө нь эзэмшиж байсан хувь оролцоогоо дахин хэмжихгүй.

МЗУ33Г. Хамтын хяналтыг хуваан эзэмшиж буй талууд, үүн дотроо хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшиж буй байгууллага нь тухайн худалдан авалтын өмнө болон дараах аль аль тохиолдолд эцсийн хяналт тавьж байгаа нэг тал буюу талуудын ерөнхий хяналтан дор байдаг бөгөөд тэрхүү хяналт нь шилждэггүй бол хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтанд 24А болон МЗУ33А-МЗУ33В параграфуудыг мөрдөхгүй.

## **Дүгнэлтийн үндэслэл**

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 37-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

## **Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмших**

...

ДҮ8. УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийг боловсруулж байх үедээ УСНББОУС3 нь үйл ажиллагааг бүрдүүлэх хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтыг хэрхэн тайлагнах талаархи заавар удирдамжийг тусган оруулах эсэхийг дахин авч үзсэн. УСНББОУС3 нь Хамтын Үйл Ажиллагаан дахь Хувь Оролцооны Худалдан Авалтын Тайлагнал (СТОУС 11-д оруулсан Нэмэлт өөрчлөлт)-д НББОУС3-ийн оруулсан заавар удирдамжийг нягталж шалгасан ба уг заавар удирдамжаас гажих улсын секторын учир шалтгаан байхгүй гэж үзсэн. Иймээс УСНББОУС3 нь энэхүү заавар удирдамжийг (УСНББОУС 40 дэх нэр томъёо ба тодорхойлолттой нийцүүлэхийн тулд нэмэлт өөрчлөлт оруулсан) УСНББОУС 37-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

## **Үлгэрчилсэн жишээ**

*Эдгээр жишээ нь УСНББОУС 37-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

...

## **Жишээ 8 – Үйл ажиллагааг бүрдүүлдэг хамтарсан үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын тайлагнал**

ҮЖ60. А, Б, В хотын захиргаанууд нь УСНББОУС 40 Улсын Секторын Нэгдэл-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэх тийм үйл ажиллагаа бүхий Г Хамтын Үйл Ажиллагааг хамтран хянадаг.

ҮЖ61. Д хотын захиргаа нь уг Г Хамтын Үйл Ажиллагаан дахь А хотын захиргааны 40 хувийн өмчлөлийн хувь оролцоог 300ТН-ээр худалдан авсан ба уг худалдан авалттай холбоотойгоор 50ТН-ийн зардал гаргасан.

ҮЖ62. Энэхүү худалдан авалтын нэг хэсэг байдлаар Д хотын захиргааны нэгдэн орсон, талуудын хооронд байгуулсан заавал биелүүлэх хэлцэлд зааснаар, зарим хөрөнгө, өр төлбөр дэх Д хотын захиргааны хувь хэмжээ нь уг Г Хамтын Үйл Ажиллагаан дахь түүний өмчлөлийн хувь хэмжээнээс өөр байх юм. Талуудын хооронд байгуулсан уг заавал биелүүлэх хэлцэлд заасанчлан, Г Хамтын Үйл Ажиллагаатай холбоотой хөрөнгө, өр төлбөр дэх Д хотын захиргааны эзэмших хувь хэмжээг дараах хүснэгтэнд харуулсан:

<b><u>Г Хамтын Үйл Ажиллагаатай холбоотой хөрөнгө, өр төлбөр дэх Д хотын захиргааны хувь хэмжээ</u></b>	
<u>Үндсэн хөрөнгө</u>	<u>48%</u>
<u>Биет бус хөрөнгө (гүүдвил хамаарахгүй)</u>	<u>90%</u>
<u>Дансны авлага</u>	<u>40%</u>
<u>Бараа материал</u>	<u>40%</u>
<u>Тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн өглөг</u>	<u>15%</u>
<u>Дансны өглөг</u>	<u>40%</u>
<u>Болзошгүй өр төлбөр</u>	<u>56%</u>

#### **Шинжилгээ**

ҮЖ63. Д хотын захиргаа нь гэрээт хэлэлцээрийн үр дүн болох тэдгээр хөрөнгө, өр төлбөрөөс өөрт хамаарах хэсгийг санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрнө (23-р параграфыг үзнэ үү).

ҮЖ64. Д хотын захиргаа нь Г Хамтын Үйл Ажиллагаан дахь уг хувь оролцоог худалдан авснаар олж эзэмшсэн хөрөнгө, хариуцсан өр төлбөрийн танин тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, ангиллын хувьд УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-д заасан худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг мөрдөнө. Яагаад гэвэл, Д хотын захиргаа нь үйл ажиллагааг бүрдүүлэх тийм ажиллагаа бүхий хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог худалдан авсан (24А параграфыг үзнэ үү).

ҮЖ65. Гэвч энэ Стандартад заасан заавар удирдамжтай зөрчилдөх тохиолдолд Д хотын захиргаа нь УСНББОУС 40 болон бусад УСНББОУС-ын худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг мөрдөхгүй. Иймээс 23-р параграфт заасанчлан, Г Хамтын Үйл Ажиллагаан дахь өөрийн хувь оролцоотой холбоотойгоор Д хотын захиргаа нь зөвхөн хамтран эзэмшиж буй хөрөнгө нэг бүр дэх өөрийн хувь хэмжээ болон хамтран хариуцах өр төлбөр нэг бүр дэх өөрийн хувь хэмжээг тэрхүү заавал биелүүлэх хэлцэлд заасан хэмжээгээр хүлээн зөвшөөрч, хэмжинэ. Д хотын захиргаа нь Г Хамтын Үйл Ажиллагаан дахь бусад талуудын хувь оролцооны хэсгийг өөрийн хөрөнгө, өр төлбөрийн оруулан тусгахгүй.

ҮЖ66. Цөөн гажих нөхцөлтэй боловч нэгтгэгч нь олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийг тэдгээрийн олж эзэмшсэн өдрийн бодит үнэ цэнээр хэмжихийг УСНББОУС 40-д шаардсан байдаг. Жишээлбэл; биет бус хөрөнгө байдлаар хүлээн зөвшөөрсөн уг дахин олж

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

эзэмшсэн эрхийн бодит үнэ цэнийг хэмжих үедээ зах зээлийн оролцогч нар нь заавал биелүүлэх хэлцлийг дахин шинэчлэх боломжит байдлыг харгалзан үздэг эсэхээс үл хамааран тэрхүү холбогдох заавал биелүүлэх хэлцлийн үлдсэн хугацаанд үндэслэн тухайн эрхийг хэмждэг. Ийм хэмжилт нь энэ Стандарттай зөрчилдөхгүй тул тэдгээр шаардлагуудыг дагаж мөрдөнө.

ҮЖ67. Иймээс Д хотын захиргаа нь Г Хамтын Үйл Ажиллагаатай холбоотой уг тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн өөрт хамаарах хэсгийн бодит үнэ цэнэ буюу УСНББОУС 40-д заасан бусад хэмжилтийг тодорхойлно. Г Хамтын Үйл Ажиллагаатай холбоотой тэдгээр тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрөөс Д хотын захиргаанд хамаарах хэсгийн бодит үнэ цэнэ буюу УСНББОУС 40-д заасан бусад хэмжилтийг дараах хүснэгтэнд харуулсан:

<b><u>Г Хамтын Үйл Ажиллагааны тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрөөс Д хотын захиргаанд хамаарах хэсгийн бодит үнэ цэнэ буюу УСНББОУС 40-д заасан бусад хэмжилт</u></b>	
<b>(ТН)</b>	
<u>Үндсэн хөрөнгө</u>	138
<u>Биет бус хөрөнгө (гүүдвил хамаарахгүй)</u>	72
<u>Дансны авлага</u>	84
<u>Бараа материал</u>	70
<u>Тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн өглөг</u>	(12)
<u>Дансны өглөг</u>	(48)
<u>Болзошгүй өр төлбөр</u>	(52)
<u>Хойшлогдсон татварын өр төлбөр (орлогын татварыг зохицуулдаг олон улсын буюу үндэсний стандартыг үзнэ үү)</u>	(24)
<b><u>Цэвэр хөрөнгө</u></b>	<b><u>228</u></b>

ҮЖ68. Тодорхойлогдох цэвэр хөрөнгөөс Д хотын захиргаанд хамаарах хэсэгт хуваарилсан дүнгээс давж хэтэрсэн, уг шилжүүлсэн төлбөрийн дүнг УСНББОУС 40-ийн дагуу гүүдвил гэж хүлээн зөвшөөрнө:

<u>Шилжүүлсэн төлбөр</u>	300 ТН
<u>Хамтын үйл ажиллагаан дахь түүний хувь оролцоотой холбоотой уг тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрөөс Д хотын захиргаанд хамаарах хэсэг</u>	228 ТН
<b><u>Цэвэр хөрөнгө</u></b>	<b><u>72 ТН</u></b>

ҮЖ69. Худалдан авалттай холбоотой 50ТН-ийн зардлыг уг хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж авахын тулд шилжүүлсэн төлбөрийн нэг хэсэг гэж үзэхгүй. Үүнийг тухайн зардал гарсан ба үйлчилгээг хүлээн авсан тайлант үеийн ашиг, алдагдалд зардал гэж хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 40-ийн 111-р параграфыг үзнэ үү).

**Жишээ 9 –Үйл ажиллагааг бүрдүүлдэг хамтын үйл ажиллагаанд ноу-хау ашиглах эрхээр хувь оруулах**

- ҮЖ70. А ба Б байгууллагууд нь янз бүрийн хэрэгцээнд зориулсан өндөр чанартай, цэнэг хураагуур үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэн явуулдаг хоёр байгууллага юм.
- ҮЖ71. Цахилгаан машины цэнэг хураагуур зохион бүтээхийн тулд эдгээр байгууллагууд нь хамтран ажиллах талаархи заавал биелүүлэх хэлцэл (Зэт Хамтын Үйл Ажиллагаа) хийсэн. А ба Б байгууллагууд нь Зэт Хамтын Үйл Ажиллагааг хамтран хянадаг. Энэхүү хэлэлцээр нь УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэх тийм үйл ажиллагаа бүхий хамтын үйл ажиллагаа юм.
- ҮЖ72. Хамтын үйл ажиллагаа эрхлэгч нар (А ба Б байгууллагууд) нь М материалыг ашигласнаар цахилгаан машины цэнэг хураагуур зохион бүтээх боломжтой гэж хэдэн жилийн дараа дүгнэсэн. Гэвч М материалын боловсруулалт нь тусгай ноу-хау шаардах бөгөөд М материалыг одоогоор зөвхөн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглаж байна.
- ҮЖ73. М материалыг боловсруулах одоо байгаа ноу-хауг ашиглах боломжтой болохын тулд А ба Б байгууллагууд нь өөр нэг хамтын үйл ажиллагаа эрхлэгч байдлаар В байгууллагыг нэгтгэн оруулахаар тохиролцсон. Тус В байгууллага нь Зэт Хамтын Үйл Ажиллагаан дахь хувь оролцоог А ба Б байгууллагуудаас худалдан авч, уг заавал биелүүлэх хэлцлийн нэг оролцогч тал болох юм.
- ҮЖ74. В байгууллагын үйл ажиллагаа нь одоогоор зөвхөн цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх явдал юм. Уг байгууллага нь М материалыг боловсруулах талаар урт хугацааны, гүнзгий мэдлэгтэй юм.
- ҮЖ75. Зэт Хамтын Үйл Ажиллагаан дахь хувь оролцооны хариуд В байгууллага нь А ба Б байгууллагуудад мөнгө төлөх бөгөөд Зэт Хамтын Үйл Ажиллагааны зорилгоор М материалыг боловсруулах өөрийн ноу-хауг ашиглах эрхийг олгох юм. Мөн түүнчлэн, В байгууллага нь М материалыг боловсруулах туршлагатай өөрийн зарим ажилтнуудыг Зэт Хамтын Үйл Ажиллагаанд туслуулан ажиллуулна. Гэвч В байгууллага нь ноу-хаугийн бүх эрхийг өөртөө хадгалж үлдэх учраас уг ноу-хаугийн хяналтыг А ба Б байгууллагууд буюу Зэт Хамтын Үйл Ажиллагаанд шилжүүлэхгүй. Тухайлбал; В байгууллага нь Зэт Хамтын Үйл Ажиллагаан дахь өөрийн оролцоог зогсоовол ямар нэг хязгаарлалт буюу А, Б байгууллагуудад ямар нэгэн нөхөн төлбөр төлөхгүйгээр М материалыг боловсруулах ноу-хауг ашиглах эрхээ буцаан авах, шилжүүлэн ажиллуулж буй ажилтнуудаа эргүүлэн татах эрхтэй.
- ҮЖ76. Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшсэн өдрөөрх уг В байгууллагын ноу-хаугийн бодит үнэ цэнэ нь 1,000 ТН байсан. Энэхүү худалдан авалтын яг өмнө, В байгууллагын санхүүгийн тайлан дахь уг ноу-хаугийн дансны үнэ нь 300 ТН байсан.

**Шинжилгээ**

ҮЖ77. В байгууллага нь УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлэх тийм хамтын үйл ажиллагаа болох Зэт Хамтын Үйл Ажиллагаан дахь хувь оролцоог олж эзэмшсэн.

ҮЖ78. Уг хамтын үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцооны худалдан авалтыг тайлагнахдаа В байгууллага нь энэ Стандарт дахь заавар удирдамжтай зөрчилдөхгүй УСНББОУС 40-д болон бусад УСНББОУС-уудад заасан худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн бүх зарчмуудыг даган мөрдөнө (24А параграфыг үзнэ үү). Иймээс В байгууллага нь уг заавал биелүүлэх хэлцлийн үр дүн болох хөрөнгө, өр төлбөрөөс өөрт хамаарах хэсгийг өөрийн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрнө (23-р параграфыг үзнэ үү).

ҮЖ79. В байгууллага нь хамтын үйл ажиллагаа эрхлэгч байдлаар Зэт хамтын үйл ажиллагаанд нэгдэн орсноор М материалыг боловсруулах ноу-хауг ашиглах эрхийг Зэт хамтын үйл ажиллагаанд олгосон. Гэвч В байгууллага нь Зэт Хамтын Үйл Ажиллагаан дахь өөрийн оролцоог зогсоовол ямар нэг хязгаарлалт буюу А, Б байгууллагуудад ямар нэгэн нөхөн төлбөр төлөхгүйгээр М материалыг боловсруулах ноу-хауг ашиглах эрхээ буцаан авах, шилжүүлэн ажиллуулж буй ажилтнуудаа эргүүлэн татах эрхтэй учраас В байгууллага нь энэхүү эрхийн хяналтыг хадгалж үлдэнэ.

ҮЖ80. Иймээс В байгууллага нь М материалыг боловсруулах ноу-хаугийн бүх эрхийг хадгалан үлддэг учраас Зэт хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцоог худалдан авсны дараа түүнийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Өөрөөр хэлбэл, В байгууллага нь уг ноу-хауг түүний 300 ТН-ийн дансны үнэд үндэслэн хүлээн зөвшөөрсөн хэвээр байна гэсэн үг юм. Хамтын үйл ажиллагаанд олгосон уг ноу-хауг ашиглах эрхийн хяналтыг хадгалан үлдсэний үр дүнд В байгууллага нь тэрхүү ноу-хауг ашиглах эрхийг өөртөө олгож байна. Иймээс В байгууллага нь уг ноу-хауг дахин хэмжихгүй бөгөөд түүнийг ашиглах эрх олголтын хувьд олз, гарзыг хүлээн зөвшөөрөхгүй.

### **СТОУС 11–тэй харьцуулалт**

УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-ийг СТОУС 11, *Хамтын Хэлэлцээр* (2011 онд гаргасан, үүн дотроо 2014 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан)-ээс үндсэндээ бэлтгэсэн. Энэ Стандартыг гаргах үед УСНББОУС3 нь СТОУС 9, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийн улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжтой байдлыг харгалзан үзээгүй байсан. Иймээс СТОУС 11 дэх СТОУС 9 гэсэн хэллэгүүдийг санхүүгийн хэрэглүүрүүдийг зохицуулдаг УСНББОУС-уудын нэрээр орлуулан хэрэглэсэн.

УСНББОУС 37 ба СТОУС 11-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

...

- ~~НББОУС 37 нь гүүдвилийг хамтарсан үйлдвэрүүдэд хуваарилах эсвэл бизнесийг бүрдүүлэх хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтыг хэрхэн тайлагнах талаархи заавар удирдамжаар хангадаггүй. Ийм заавар удирдамжийг СТОУС 11-д тусгасан байдаг.~~

...

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 40-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Зорилго (1-р параграф)

ДҮ1. Улсын секторын нэгдлийг зохицуулдаг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) байгаагүй үед УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга* нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний бусад стандартуудыг харгалзан үзэхийг улсын секторын байгууллагуудад чиглэл болгодог байсан. Улсын секторын нэгдлийн хувьд улсын секторын байгууллагууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС®) 3, *Бизнесийн Нэгдэл*-ийг харгалзан үзэж болох юм. Гэвч СТОУС 3 нь бүх бизнесийн нэгдлийг худалдан авалтын арга ашиглан тайлагнахыг шаарддаг. Нэгдэгч аж ахуйн нэгжүүдийн аль нь ч бусаддаа хяналт тавьдаггүй “хувь оролцооны жинхэнэ нэгдэл” буюу “хувь оролцооны адил тэнцүү нэгдэл” нь маш ховор бөгөөд үнэндээ огт байдаггүй гэж Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ®) нь СТОУС 3-ыг боловсруулж байх үедээ дүгнэсэн байдаг. Хариулт өгсөн хүмүүс болон бусад сонирхогч талууд нь хувь оролцооны жинхэнэ нэгдэл буюу хувь оролцооны адил тэнцүү нэгдлийг бусад бизнесийн нэгдлээс ялгах хоёрдмол утгагүй ба тохиолдлын бус хил хязгаарыг санал болгох боломжгүй гэдгийг НББОУСЗ нь мөн ажигласан бөгөөд ийм үйл ажиллагааны хил хязгаарыг тогтоох боломжгүй гэж дүгнэсэн (СТОУС 3-ын ДҮ35-ыг үзнэ үү). Иймээс ийм нэгдэлд зориулсан нягтлан бодох бүртгэлийн тусдаа шаардлагуудыг тодорхойлох хэрэггүй гэж НББОУСЗ шийдвэрлэсэн.

ДҮ2. Улсын секторын хувьд хувь оролцооны нэгдэл буюу нийлүүлэлт нь нэгдлийн хамгийн нийтлэг хэлбэр гэж олон хүмүүс үздэг. Үүний улмаас улсын секторын байгууллагууд нь улсын секторын нэгдлийг тайлагнахдаа СТОУС-ын Стандартуудыг мөрддөггүй байж болох юм. Энэ нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (НЗСТ)-д ийм нэгдлийг тууштай буюу тохиромжтой тайлагнадаггүй байж болох юм гэсэн санааг илэрхийлнэ. Иймээс хэрэглэгчид нь улсын секторын нэгдлийн төрлийг тодорхойлох ба түүний шинж төрөл, санхүүгийн үр нөлөөг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг олж авах боломжгүй байж болох юм. Энэхүү Стандарт нь улсын секторын байгууллагууд улсын секторын нэгдлийг хэрхэн тайлагнах талаар тууштай ба зэрэгцүүлэгдэх байдлыг дэмжин бүрдүүлнэ гэж УСНББОУСЗ найдаж байна.

### Үйл явц

ДҮ3. Энэхүү Стандартыг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* дахь хяналтын хэлэлцүүлгийг харгалзан үзсэн. УСНББОУС 35-д тодорхойлсон, хяналт нь энэ Стандарт дахь улсын секторын нэгдлийн ангилалд хэрхэн нөлөөлөх хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Шаардлагагүй зөрүүтэй байдал үүсгэхээс



зайлсхийх зорилгоор УСНББОУСЗ нь *Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн Гарын Авлага 2014* (ЗГССГА 2014)-д заасан, нэгдлийн талаархи заавар удирдамжийг мөн анхаарч үзсэн. Түүнчлэн, УСНББОУСЗ нь СТОУС 3 болон үндэсний стандарт тогтоогчдын боловсруулсан нэгдлийн талаархи заавар удирдамжийг судалсан.

*Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС)-тай уялдуулалт*

ДҮ4. Энэхүү Стандартыг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь *Засгийн Газрын Санхүүгийн Статистик* (ЗГСС)-т заасан, улсын секторын нэгдлийн арга хандлагыг харгалзан үзсэн.

Худалдан авалтаар ажил гүйлгээ хийдэг, харин нийлүүлэлтээр нэгжүүдийн зөвхөн дахин ангилал хийгдэж болох юм гэсэн зарчимд үндэслэн ЗГСС-ийн заавар нь худалдан авалт ба нийлүүлэлтийг өөр хооронд нь ялган тодорхойлдог.

“Зах зээлийн нэгж”-ийг төрийн өмчид авах эсвэл хувьчлах (өөрөөр хэлбэл, засгийн газрын хяналтыг тогтоох эсвэл хяналтаас гаргах) үед ажил гүйлгээ хийгддэг бөгөөд тухайн ажигласан ажил гүйлгээний үнэтэй уялдуулан түүний дүнг ЗГСС-т өмчийн ажил гүйлгээ байдлаар бүртгэдэг. Үнэлгээний аливаа өөрчлөлтийг тухайлбал, засгийн газрын өмчийн ногдол хувийн эхний үлдэгдэл ба ажил гүйлгээний эцсийн үнийн хоорондох өөрчлөлтийг тухайн засгийн газрын олгосон цэвэр зээл эсвэл авсан цэвэр зээлд нөлөөлөхгүйгээр дахин үнэлгээний үр нөлөө гэж бүртгэнэ. Нийлүүлэлтийн хувьд, “институцийн нэгжүүд”-ийн секторжилтонд гол үр нөлөө үзүүлдэг.

Нэгжүүд нь нийлүүлэлтээс өмнө төв засгийн газрын нэг секторт буюу түүний дэд секторт харъяалагдаж байсан бол тухайн нийлүүлэлт нь уг сектор буюу дэд секторын тоо мэдээнд нөлөө үзүүлэхгүй. Жишээлбэл; орон нутгийн хоёр засаг захиргааны аль алиныг тухайн орон нутгийн засаг захиргааны секторт нэгэнт ангилсан тохиолдолд тэдгээрийн нийлүүлэлт нь уг орон нутгийн засаг захиргааны секторын хувьд үр дүнг өөрчлөхгүй.

Харин нэг дэд секторын нэгжийг нөгөө дэд секторын нэгжтэй нийлүүлсэн тохиолдолд тухайн нийлж буй нэгжүүдийг түүний харъяалагдаж байсан сектороос хасаж, нэгжийн дахин ангилал хийснээр тэрхүү нийлүүлсэн шинэ нэгжийн секторт нэмж оруулна (үүнийг ЗГСС-т “хөрөнгө, өр төлбөрийн тоо хэмжээний бусад өөрчлөлт” байдлаар бүртгэнэ). Жишээлбэл; орон нутгийн засаг захиргааны нэгжийг мужийн засгийн газартай нийлүүлсэн бол тухайн нэгжийг орон нутгийн засаг захиргааны дэд сектороос мужийн засгийн газрын дэд секторт дахин ангилах юм.

ДҮ5. ЗГСС-ын арга хандлага нь дараах шалтгааны улмаас энэ Стандартын хувьд улсын секторын нэгдлийг ангилах тохиромжтой суурь болохгүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн:

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (a) ЗГСС-ын арга хандлага нь УСНББОУС-уудтай нийцэхгүй маш олон ойлголт ухагдахуунд үндэслэдэг, тухайлбал;
    - (i) Институцийн нэгжүүдийг тэдгээрийн эдийн засгийн шинж төрөлд үндэслэн секторуудад ангилах ангилал; ба
    - (ii) Зах зээлийн үйлдвэрлэгчид ба зах зээлийн бус үйлдвэрлэгчдийн хоорондох ялгаа.
  - (б) ЗГСС-т нийлүүлэлт нь ажил гүйлгээг бүртгэхгүйгээр тэдгээр нэгжүүдийн дахин ангиллаар үүсэж болох бөгөөд энэ нь УСНББОУС-ын арга хандлагатай нийцдэггүй; ба
  - (в) Төв засгийн газрын нэг сектор буюу түүний дэд секторын хүрэн дэх улсын секторын нэгдэл нь ЗГСС-ын тоо мэдээнд нөлөө үзүүлдэггүй, харин УСНББОУС нь бие даасан байгууллагуудын өөрчлөлтийг тайлагнахыг шаарддаг.
- ДҮ6. ЗГСС ба УСНББОУС дахь өөр өөр арга хандлагууд нь ижил төсөөтэй тайлагналд хүргэж болно гэдгийг УСНББОУСЗ нь энэ дүгнэлтийг гаргах үедээ тэмдэглэсэн. Жишээлбэл:
- (a) Төрийн өмчид авах үйл ажиллагааг энэхүү хоёр арга хандлагын аль алины дагуу худалдан авалт гэж тайлагнах магадлалтай байдаг; ба
  - (б) Нэгдэгч үйл ажиллагаанууд нь нягтлан бодох бүртгэлийн нэг ижил бодлогыг өмнө нь баримталж байсан тохиолдолд хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга нь ЗГСС-ийн дахин ангиллын арга хандлагатай ижил тайлагналд хүргэдэг.

### Цар хүрээ (2-4-р параграф)

- ДҮ7. УСНББОУСЗ нь улсын секторын нэгдлийн хувьд дараах зүйлсийг хамарсан хоёр Стандарт боловсруулахаар эхлээд судалж байсан:
- (a) Арилжааны ажил гүйлгээнээс үүсэх байгууллагын нэгдэл – СТОУС 3-тай хязгаарлагдмал байдлаар нийцүүлэх төсөл; ба
  - (б) Арилжааны бус ажил гүйлгээнээс үүсэх байгууллагын нэгдэл – улсын секторт тусгайлан хамаарах төсөл.
- ДҮ8. 2009 оны 5 дугаар сард УСНББОУСЗ нь Саналын төсөл (СТ) 41, *Арилжааны Ажил Гүйлгээнээс Үүссэн Байгууллагын Нэгдэл*-ийг гаргасан бөгөөд энэ нь СТОУС 3-тай хязгаарлагдмал байдлаар нийцүүлэх төсөл юм. СТ 41-ийн зөвлөлдөх үйл явцын үр дүнд УСНББОУСЗ нь дараах шалтгааны улмаас энэ арга хандлагыг цаашид үргэлжлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн:
- (a) СТОУС 3 нь тохиролцоот худалдан авалтыг өөрийн цар хүрээнд хамруулсан байдаг. Иймээс СТОУС 3-ыг байгууллагын арилжааны бус наад зах нь зарим нэгдэлд бас мөрддөг гэж үзэж болохоор байна. Байгууллагын арилжааны ба арилжааны бус бүх нэгдлийн

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

хооронд тодорхой хил заагийг тогтооход төвөгтэй байж болох юм гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

- (б) Нэгдлийн аль нэг тал нь бусад талуудын хяналтыг олж аваагүй тохиолдолд тухайн нэгдлийг арилжааны ажил гүйлгээнээс үүссэн байгууллагын нэгдэл гэж ангилах, ингэснээр СТ41-ийн дагуу худалдан авалт гэж тайлагнах шаардлагатай эсэх нь тодорхойгүй байдаг.
- ДҮ9. Үүний дараа УСНББОУСЗ нь улсын секторын бүх нэгдлийг зохицуулах нэг стандарт боловсруулахаар шийдвэрлэсэн. 2012 оны 6 дугаар сард гаргасан, Зөвлөлдөх Баримт Бичиг (ЗББ), *Улсын Секторын Нэгдэл*-д энэхүү өргөн цар хүрээний талаар тусгасан. ЗББ-т хариулт ирүүлсэн хүмүүс нь энэхүү өргөн цар хүрээг дэмжсэн.
- ДҮ10. Иймээс УСНББОУСЗ нь энэ Стандартыг зөвхөн хязгаарлагдмал гажих нөхцөлтэйгээр улсын секторын бүх нэгдэлд мөрдөх хэрэгтэй гэж шийдвэрлэсэн. Улсын секторын нэгдэл нь тусдаа үйл ажиллагаануудыг улсын секторын нэг байгууллагад нэгтгэн оруулах явдал гэж энэ Стандартад тодорхойлсон. Энэ тодорхойлолт нь бизнесийн нэгдэлтэй адилаар байгууллагуудыг биш, харин үйл ажиллагаануудыг нэгтгэн оруулах нь улсын секторын нэгдэл гэж үзсэн бөгөөд ингэснээр тухайн байгууллагын үлдсэн хэсгээс тусад нь удирдан зохицуулж болох тэрхүү байгууллагын хэсгийг хамруулж болох юм.
- ДҮ11. Энэ Стандартын цар хүрээний талаархи шийдвэрийг гаргахдаа УСНББОУСЗ нь ерөнхий хяналтанд буй улсын секторын нэгдлийг тусган оруулахыг зөвшөөрсөн. Эдгээрийг СТОУС 3-ын цар хүрээнд хамруулдаггүй боловч улсын секторын бүх нэгдлийг энэ Стандартын цар хүрээнд тусган оруулах нь ач холбогдолтой гэж УСНББОУСЗ үзсэн.

### *Цар хүрээнд хамаарахгүй зүйлс*

- ДҮ12. Хамтын хэлэлцээр буюу хамтарсан үйлдвэр үүсгэн байгуулалтанд энэ Стандартыг мөрдөх хэрэггүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. УСНББОУСЗ нь үүнийг ЗББ-т дараах байдлаар заасан:
- “Хамтарсан үйлдвэрийг үүсгэн байгуулах суурь үндэслэл болох ойлголт ухагдахуун нь бусад нэгдлүүдээс өөр бөгөөд иймээс хяналтыг хамтран тогтоохоор шийдвэрлэсэн тусдаа байгууллагуудаас үүнийг үүсгэн байгуулдаг, өөрөөр хэлбэл тусдаа байгууллагууд нь уг хамтарсан үйлдвэрийг бүрдүүлэх үйл ажиллагаануудын хувьд хамтын хяналттай байдаг. Хамтын хяналтын талаархи ойлголт ухагдахуун нь өөрийн үүсгэн байгуулалтыг тухайн хамтарсан үйлдвэр хэрхэн тайлагнах эсэхэд нөлөөлөх асуудлуудыг үүсгэж болох юм.”
- ДҮ13. Улсын секторын нэгдлийг ангилах өөр өөр арга хандлагуудыг энэ Стандартад тусгасан түүний шалтгаан үндэслэл нь одоо ч хүчин төгөлдөр байгаа эсэхийг УСНББОУСЗ нь энэ Стандартыг боловсруулах үедээ хэлэлцсэн. УСНББОУСЗ нь энэ Стандартад авч үзсэн асуудлуудыг

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

хамтын хяналтын талаархи ойлголт ухагдахуунд тусгадаггүй гэж дүгнэсэн бөгөөд хамтын хэлэлцээр буюу хамтарсан үйлдвэрийн үүсгэн байгуулалтыг түүний цар хүрээнээс хасахыг зөвшөөрсөн.

ДҮ14. Хоёр буюу хэд хэдэн хамтын хэлэлцээрийн нэгдэл хийгдэж болно гэж УСНББОУСЗ тэмдэглэсэн. Ийм нэгдэл нь шинэ хамтын хэлэлцээр үүсгэн бий болгох үр дүнтэй тохиолдолд энэ нь УСНББОУС 40-ийн цар хүрээнд хамаарахгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. УСНББОУСЗ нь нэг буюу хэд хэдэн хамтын хэлэлцээрийг өөр нэг хамтын хэлэлцээр худалдан авснаар нэгдэл үүсэж болно гэж тэмдэглэсэн. Энэ тохиолдолд уг худалдан авсан хамтын хэлэлцээрт өмнө нь хяналт тавьдаг байсан байгууллагууд нь тэрхүү хамтын хяналтаа алддаг. Ийм нэгдэл нь УСНББОУС 40-ийн цар хүрээнд хамаарах худалдан авалт болох юм.

ДҮ15. Хяналтанд буй байгууллагад хөрөнгө оруулсан тухайн хөрөнгө оруулалтын байгууллагын ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шаардлагатай худалдан авалтыг энэ Стандартын цар хүрээнээс хасахыг УСНББОУСЗ мөн хүлээн зөвшөөрсөн. Ийм ажил гүйлгээг улсын секторын нэгдэл биш, харин хөрөнгө оруулалт гэж үздэг. Ийм ажил гүйлгээний тайлагналын шаардлагуудыг УСНББОУС 35-д заасан.

### *СТ 60, Улсын Секторын Нэгдэл-д өгсөн хариултууд*

ДҮ16. 2016 оны 01 дүгээр сард УСНББОУСЗ нь өөрийн саналыг СТ 60, *Улсын Секторын Нэгдэл*-д тусган гаргасан. СТ 60-д хариулт өгсөн хүмүүс нь уг санал болгож буй цар хүрээ болон гажих нөхцлүүдийг ерөнхийдөө дэмжсэн. УСНББОУСЗ нь хариултуудыг харгалзан үзсэн бөгөөд цар хүрээг өөрчлөх шаардлагагүй гэдгийг зөвшөөрсөн. Ингэхдээ УСНББОУСЗ нь түр зуурын шинжтэй нэгдлийг энэ Стандартын цар хүрээнд тусган оруулсан гэж тэмдэглэсэн. Жишээлбэл; тухайн компанийн санхүүгийн байдал сайжирмагц буцаан худалдан борлуулах санаа зорилготойгоор хувийн хэвшлийн компанид “авралын арга хэмжээ” үзүүлэх. Ийм нэгдлийг энэ Стандартын цар хүрээнд хамруулах нь түр зуур хяналтанд буй байгууллагын хувьд нягтлан бодох бүртгэлийн өөр арга хандлага шаардлагагүй гэж УСНББОУС 35-ыг боловсруулах үедээ гаргасан шийдвэртэй нийцнэ гэж УСНББОУСЗ тэмдэглэсэн.

### **Улсын секторын нэгдлийн ангилал (7-14-р параграф)**

ДҮ17. Арилжааны ажил гүйлгээгээр үүссэн байгууллагын нэгдэл ба арилжааны бус ажил гүйлгээгээр үүссэн байгууллагын нэгдлийг өөр хооронд нь ялган зааглах нь ирээдүйн УСНББОУС-ын хувьд тохиромжтой суурийг бүрдүүлэхгүй гэж УСНББОУСЗ нь СТ 41-ээр хүлээн авсан хариултуудын үр дүнд дүгнэсэн. УСНББОУСЗ-өөс гаргасан баримт бичгүүд дэх “арилжааны ажил гүйлгээ”-ний тодорхойлолтыг харгалзан үзвэл, 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал гэх мэт эдийн засгийн хямралын үеийн засгийн газрын ихэнх оролцоо нь худалдан авалтын тодорхойлолтыг

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

хангахгүй гэдгийг харуулж байна. Ийм “авралын арга хэмжээ”-г нийлүүлэлт гэж тодорхойлох нь зохисгүй гэж УСНББОУСЗ үзсэн.

ДҮ18. Мөн УСНББОУСЗ нь СТОУС 3-ыг байгууллагад биш, харин “бизнес”-ийн хувьд мөрддөг гэдгийг тэмдэглэсэн. Түүнчлэн, байгууллагын хувьд мөрдөх тохиолдолд бизнесийн тодорхойлолт нь уг байгууллагын үлдсэн хэсгээс тусад нь удирдаж болох тухайн байгууллагын тийм хэсэгт мөн хамаарах юм. ЗББ дэх өөрийн арга хандлагыг боловсруулахдаа УСНББОУСЗ нь эдгээр асуудлуудыг харгалзан үзсэн.

### *Зөвлөлдөх Баримт Бичиг, “Улсын Секторын Нэгдэл” дэх ангиллын арга хандлага*

ДҮ19. ЗББ-т тусгасан арга хандлага нь нэгдлийн оролцогч талууд ерөнхий хяналтанд байх үеийн нэгдэл ба нэгдлийн оролцогч талууд нэг эцсийн хяналт тавигч байгууллагын хяналтанд байхгүй, өөрөөр хэлбэл ерөнхий хяналтанд байдаггүй үеийн нэгдлийг өөр хооронд нь ялган авч үзсэн. Нэг тал нь нөгөө талын хяналтыг олж авдаг нэгдэл (ЗББ-т худалдан авалт гэж үзсэн) ба нэгдлийн аль нэг тал бусад талуудын хяналтыг олж авдаггүй нэгдлийг (ЗББ-т нийлүүлэлт гэж үзсэн) өөр хооронд нь мөн ялгаж үзсэн.

ДҮ20. УСНББОУСЗ нь улсын секторын нэгдлийн ангилалыг тодорхойлоход хяналтын талаархи ойлголт ухагдахуун чухал ач холбогдолтой гэж үзсэн. Хяналт нь ихэнх санхүүгийн тайлагналын үндэслэл болдог. Өмнөх стандарт болох УСНББОУС 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайланд* заасантай нэгэн адилаар, байгууллага нь өөрийн хяналтанд буй бусад байгууллагуудыг нэгтгэхийг УСНББОУС 35-д шаардсан байдаг. Засгийн Газрын Санхүүгийн Статистик нь хяналтын хувьд УСНББОУС 35 ба УСНББОУС 6-гийн аль алинд заасантай ижил хандлагыг мөрддөг болохыг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн.

ДҮ21. Дээр дурдсантай адилаар, хяналт нь хөрөнгийг хүлээн зөвшөөрөх үед чухал ач холбогдолтой хүчин зүйл байдаг. *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* (Онолын Үзэл Баримтлал)-ын 5.6-р параграфт хөрөнгийг “өнгөрсөн үйл явдлын үр дүнд байгууллага одоо хяналтандаа оруулсан нөөц” гэж тодорхойлсон.

ДҮ22. Иймээс хяналт нь улсын секторын нэгдлийн ангиллыг тодорхойлох зохих эхлэлийн цэг гэж УСНББОУСЗ тодорхойлсон. Үүний үр дүнд улсын секторын нэгдлийг ангилахад хяналтын гүйцэтгэх үүргийн талаархи УСНББОУСЗ-ийн нэн тэргүүний байр суурийг ЗББ-т дараах байдлаар тусган оруулсан:

“Нийлүүлэлтийг худалдан авалтаас ялгах гол тодорхойлогч шалгуур нь нийлүүлэлтийн үед тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын аль нь ч бусад үйл ажиллагаануудын хяналтыг олж авдаггүй явдал юм.”

ДҮ23. Ерөнхий хяналтанд буй улсын секторын нэгдлийн оролцогч талуудыг уг нэгдлийн өмнө болон дараа тухайн нэг байгууллага эцсийн эцэст хянадаг гэж УСНББОУСЗ нь ЗББ-ийг боловсруулах үедээ тайлбарласан. Энэ нь

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

ерөнхий хяналтан доор хийгдсэн нэгдэл ба ерөнхий хяналтаас гадуур хийгдсэн нэгдлийн хоорондох эдийн засгийн дараах ялгаатай байдалд хүргэдэг:

- (а) Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх (өөрөөр хэлбэл, ерөнхий хяналтан доор) байгууллагуудын хоорондох улсын секторын нэгдэл нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын эдийн засгийн нөөцийг өөрчилдөггүй;
- (б) Ерөнхий хяналтанд буй улсын секторын нэгдлээс үүссэн аливаа ашиг, алдагдлыг тухайн эцсийн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн НЗСТ-д бүрэн устгаж цэвэрлэдэг; ба
- (в) Ерөнхий хяналтанд буй улсын секторын нэгдлийн хувьд ямар нэгэн төлбөр шилжүүлэх эсэхийг (хэрэв төлбөр шилжүүлсэн бол уг төлбөрийн дүнг) уг эцсийн хяналт тавигч байгууллага нь тусгайлан зааж болно.

Эдгээр ялгаатай талууд нь ерөнхий хяналтанд буй улсын секторын нэгдлийн нягтлан бодох бүртгэлийн аргад нөлөө үзүүлж болох юм.

ДҮ24. ЗББ дэх арга хандлага нь УСНББОУСЗ-ийн дараах байр суурийг тусгасан:

- (а) Ерөнхий хяналтан доор хийгдсэн нэгдэл ба ерөнхий хяналтаас гадуур хийгдсэн нэгдлийн хоорондох эдийн засгийн ялгаатай байдал нь тэдгээрийн нягтлан бодох бүртгэлийн аргад нөлөө үзүүлж болох юм; ба
- (б) Худалдан авалтыг тухайн хяналтанд үндэслэн нийлүүлэлтээс ялган салгаж үзэх хэрэгтэй.

ДҮ25. ЗББ-т хариулт ирүүлсэн зарим хүмүүс тухайн саналыг дэмжсэн, мөн адилтгах тооны хүмүүс уг саналыг хүлээн зөвшөөрөөгүй. Саналыг зөвшөөрөөгүй хүмүүс нь зөвхөн хяналтанд үндэслэн худалдан авалтыг нийлүүлэлтээс ялгах нь улсын секторын нөхцөл байдлыг тусгахгүй гэж үзэж байсан. Ийм хариулт ирүүлсэн хүмүүс нь тухайлбал, дараах зүйлсийг илэрхийлсэн:

- (а) Улсын секторын нэгдлийн үр дүнд үйл ажиллагаануудын хяналтыг олж авсан байгууллагыг тодорхойлох боломжтой боловч нэгтгэгчийг тогтоох боломжгүй үед улсын секторын нэгдэл хийгдэж болох юм. СТОУС 3-ын дагуу холбогдох талууд дахь өмчлөлийн хувь оролцоог шинжилснээр нэгтгэгчийг тодорхойлж болно. Гэвч тэдгээр байгууллагууд дахь тоолж болох өмчлөлийн хувь оролцоогүй байж болох улсын секторын хувьд ийм шинжилгээг хийх боломжгүй байдаг. Үйл ажиллагаануудын хяналтыг олж авч буй байгууллага нь тухайн нэгдлээс өмнө оршин байгаагүй байж болох бөгөөд хэрэв уг байгууллага дахь тоолж болох өмчлөлийн хувь оролцоогүй бол нэгтгэгчийг тодорхойлох боломжгүй байна.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (б) Дээд түвшний засгийн газрын байгууллага нь тухайн нэгдлийн оролцогч бүх талуудад улсын секторын нэгдлийг тулган хүлээлгэж болох юм. Жишээлбэл; төв засгийн газар нь орон нутгийн засаг захиргааны нэгжүүдийн хүсэлтийг үл харгалзан тэдгээрийг нэгтгэх эрх зүйн акт гаргаснаар орон нутгийн засаг захиргааг дахин зохион байгуулж болно.

ДҮ26. ЗББ-т тусгасан саналуудыг хүлээн зөвшөөрөөгүй, хариулт өгсөн хүмүүс нь улсын секторын нэгдлийг ангилал олон тооны хувилбар сууриудыг санал болгосон. Үүнд:

- (а) Төлбөр шилжүүлэх эсэх хувилбарууд;
- (i) Нэгдлийн нэг хэсэг байдлаар төлбөр шилжүүлсэн;
  - (ii) Нэгдлийн нэг хэсэг байдлаар томоохон төлбөр шилжүүлсэн;
  - (iii) Нэгдлийг зах зээлийн үнэ цэнээр гүйцэтгэсэн;
  - (iv) Ерөнхий хяналтаас гадуурх худалдан авалтыг (төлбөрийн шилжүүлэлтийг агуулсан) бусад бүх нэгдлүүдээс ялган салгах;
  - (v) Тухайн нэгдэл нь “худалдаа арилжааны мөн чанар”-тай (төлбөрийн шилжүүлэлтийг агуулсан) эсэхэд үндэслэн ерөнхий хяналтан доорх нэгдлүүдийг өөр хооронд нь ялган салгах.
- (б) Улсын секторын нэгдлийг албан журмаар эсвэл сайн дураар хийсэн эсэх.

*СТ 60, “Улсын Секторын Нэгдэл”дэх ангиллын арга хандлагын боловсруулалт*

ДҮ27. УСНББОУСЗ нь ЗББ-т ирүүлсэн хариултуудыг авч үзсэн. ЗББ-т тусгасан ангиллын арга хандлага нь улсын секторын нөхцөл байдлыг ямагт илэрхийлэхгүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Иймээс УСНББОУСЗ нь улсын секторын нэгдлийн ангиллыг дахин авч үзэхийг зөвшөөрсөн.

ДҮ28. Хариулт өгсөн хүмүүсээс санал болгосон аливаа арга хандлага нь ангиллын хувилбар сууриар хангах эсэхийг УСНББОУСЗ нь энэ үйл явцын нэг хэсэг байдлаар авч үзсэн. Эдгээр арга хандлагууд нь дараах учир шалтгааны улмаас тохиромжгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн:

- (а) Төлбөр шилжүүлэлт нь худалдан авалтыг нийлүүлэлтээс ялгахад дангаараа хангалтгүй гэсэн дүгнэлтэнд УСНББОУСЗ хүрсэн. Дээрх ДҮ17-р параграфт дурдсанчлан, худалдан авалтыг арилжааны ажил гүйлгээ гэж тодорхойлох нь “авралын арга хэмжээ”-г нийлүүлэлт гэж тодорхойлоход хүргэх юм. Үүнтэй адилаар, төлбөрийг нэгтгэгч шилжүүлэх шаардлагатай байдлаар худалдан авалтыг тодорхойлсон бол энэ нь “авралын арга хэмжээ”-г нийлүүлэлт гэж ангилахад хүргэж болох юм. Томоохон төлбөр шилжүүлэх эсвэл улсын секторын нэгдлийг зах зээлийн үнэ цэнээр

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

хийхийг шаардсан худалдан авалтын тодорхойлолтонд тохиролцоот худалдан авалт гэх мэт асуудлуудыг авч үздэггүй (дээрх ДҮ8(а) параграфт авч хэлэлцсэн).

- (б) Улсын секторын нэгдлийг албан журмаар эсвэл сайн дураар хийсэн эсэх нь улсын секторын нэгдлийг ангилах хангалттай мэдээллийг дангаараа бүрдүүлдэггүй гэж УСНББОУСЗ үзсэн. Улсын секторын нэгдлийн албан журмын эсвэл сайн дурын шинж төрөл нь тухайн нэгдлийн үр дүнгийн биш, харин үйл явцын талаархи мэдээллээр хангадаг. Албан журмын эсвэл сайн дурын шинж чанартай эсэхээс үл хамааран улсын секторын нэгдлүүд нь эдийн засгийн янз бүрийн үр дагавартай байж болно. Тухайн нэгдлийн үр дүнг харгалзан үзэхгүйгээр улсын секторын нэгдлийг ангилах боломжтой гэж УСНББОУСЗ үздэггүй. Иймээс улсын секторын нэгдлийн албан журмын эсвэл сайн дурын шинж төрөлд зөвхөн үндэслэсэн ангилал нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангана гэж УСНББОУСЗ үзэхгүй байна.

ДҮ29. УСНББОУСЗ нь улсын секторын нэгдлийг ангилахад хяналтын гүйцэтгэх үүргийг нягтлан үзсэн бөгөөд хяналт нь нэгдлийг худалдан авалт эсвэл нийлүүлэлт эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой хүчин зүйл хэвээр байна гэж дүгнэсэн. Нэгдлийн оролцогч нэг тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг зөвхөн тийм тохиолдолд худалдан авалт үүсэж болно гэдгийг УСНББОУСЗ нь энэхүү дүгнэлтийг гаргах үедээ онцлон тэмдэглэсэн (үүнийг дээрх ДҮ25(а) параграфт илүү дэлгэрэнгүй авч хэлэлцсэн). Иймээс аль хүчин зүйл нь хяналтын ойлголт ухагдахууныг ач холбогдолтойгоор дэмжин гүйцээх эсэхийг тодорхойлохын тулд УСНББОУСЗ нь ЗББ-т хариулт ирүүлсэн хүмүүсийн санал болгосон хүчин зүйлсийг нягталж шалгасан.

ДҮ30. УСНББОУСЗ нь дараах хүчин зүйлсийг авч хэлэлцсэн бөгөөд улсын секторын нэгдлийг ангилах үедээ хяналтын ойлголт ухагдахууныг дэмжин гүйцээхэд эдгээр нь ач холбогдолтой байж болно гэдгийг хүлээн зөвшөөрсөн:

- (а) **Төлбөр.** Улсын секторын нэгдлээр төлбөр шилжүүлэх эсэх нь уг нэгдлийг ангилахад хамааралтай гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Худалдан авалт нь ерөнхийдөө төлбөрийг агуулдаг, харин нийлүүлэлтийн үед төлбөр хийдэггүй. Дээрх ДҮ28(а) параграфт дурдсан учир шалтгааны хувьд, төлбөр шилжүүлэлт нь дангаараа дүгнэлтийн шинжтэй болохгүй, харин яагаад төлбөр шилжүүлсэн эсвэл шилжүүлээгүй шалтгааныг харгалзсанаар тухайн нэгдлийн шинж төрлийн талаар илүү их мэдээлэл олж авна гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.
- (б) **Арилжааны ажил гүйлгээ.** Худалдан авалт нь арилжааны бус ажил гүйлгээтэй харьцуулахад арилжааны ажил гүйлгээний үед гарч тохиолдох илүү их магадлалтай гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Гэвч байгууллагын арилжааны ба арилжааны бус бүх нэгдлийн хооронд тодорхой хил заагийг тогтооход төвөгтэй байж



болох юм гэдгийг УСНББОУСЗ өмнө дурдсан (дээрх ДҮ8(а) параграфыг үзнэ үү). Төлбөр шилжүүлсэн эсвэл шилжүүлээгүй учир шалтгааныг харгалзсанаар тухайн улсын секторын нэгдэл нь арилжааны ажил гүйлгээ эсвэл арилжааны бус ажил гүйлгээ эсэх талаархи мэдээллийг тодорхойлж болно гэсэн дүгнэлтэнд УСНББОУСЗ хүрсэн. Иймээс УСНББОУСЗ нь энэ хүчин зүйлийг төлбөрөөс тусад нь үнэлэх шаардлагагүй гэж дүгнэсэн.

- (в) **Тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоо.** Үйл ажиллагаан дахь тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоо байгаа эсэх нь тухайн улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарт нөлөөлж болно гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Хэрэв тухайн үйл ажиллагаанд тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоогүй бол төлбөрийг хүлээн авах эрх бүхий тал байхгүй учраас төлбөрийг шилжүүлэхгүй. Энэ нь төлбөрийг хүлээн авах эзэн ямагт байдаг худалдан авалтаас тухайн нэгдлийг ялган салгаж өгдөг. Тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоогүй байдал нь төлбөрийг яагаад шилжүүлээгүй гэсэн шалтгаан байж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь энэ хүчин зүйлийг төлбөрөөс тусад нь үнэлэх шаардлагагүй гэж дүгнэсэн.
- (г) **Шийдвэр гаргах үйл явц.** Улсын секторын нэгдлийн талаар аль тал шийдвэр гаргах боломжтой эсэхийг харгалзан үзэх нь тухайн нэгдлийг ангилахтай холбоотой чухал мэдээллээр хангаж болох юм гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Хэвийн хэвшлийн хувьд нэгдэл нь ихэвчлэн сайн дурын үндсэн дээр хийгддэг, хамгийн наад зах нь нэгтгэгчийн зүгээс сайн дураар хийдэг. Улсын секторын хувьд шийдвэр гаргах үйл явцад бусад талууд оролцож болох юм. Нэгдлийн оролцогч талууд сайн дурын үндсэн дээр оролцох боломжит байдал нь тухайн нэгдлийн эдийн засгийн шинж төрөлд, улмаар түүний ангилалд нөлөөлж болох юм.
- (д) **Албан журам.** Улсын секторын хувьд засгийн газрын дээд түвшний байгууллага нь тухайн нэгдэлд оролцогч талуудыг санхүүгийн тайлагналын зорилгоор хянадаг эсэхээс үл хамааран улсын секторын нэгдлийг тулган хийлгэж болох юм. Жишээлбэл; төв засгийн газар нь нэгдэх чиглэлийг орон нутгийн засаг захиргааны зарим нэгжүүдэд өгснөөр тухайн орон нутгийн засаг захиргаанд бүтцийн өөрчлөлт хийж болно. Ийм албан журам нь улсын секторын нэгдлийн ангилалд хамааралтай гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн боловч шийдвэр гаргалтыг харгалзсанаар тухайн албан журмын талаархи мэдээллийг олж авна гэж үзсэн. Иймээс УСНББОУСЗ нь энэ хүчин зүйлийг шийдвэр гаргах үйл явцаас тусад нь үнэлэх шаардлагагүй гэж дүгнэсэн.
- (е) **Ерөнхий хяналт.** ЗББ-ийг боловсруулах үедээ УСНББОУСЗ нь ерөнхий хяналтан доор хийгдсэн улсын секторын нэгдэл ба ерөнхий хяналтаас гадуур хийгдсэн улсын секторын нэгдэл хоорондох эдийн засгийн ялгаатай талуудыг тодорхойлсон (дээрх

ДҮ23-р параграфыг үзнэ үү). Ямар нэг төлбөр шилжүүлэх эсэхийг тусгайлан тодорхойлох уг хяналт тавигч байгууллагын чадвар боломж нь тухайн нэгдлийн ангилалд хамааралтай гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн боловч энэ нь шийдвэр гаргах үйл явцын элемент гэж үзсэн. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын эдийн засгийн нөөц нь ерөнхий хяналтан доорх нэгдлийн хувьд өөрчлөгддөггүй бөгөөд аливаа ашиг, алдагдлыг нэгтгэлийн явцад устгаж, цэвэрлэдэг байдал нь хяналтанд буй байгууллагад биш, харин хяналт тавигч байгууллагад хамааралтай гэж үздэг. Хяналтанд буй байгууллага нь тухайн нэгдлийн хувьд тайлагнагч байгууллага болох тул УСНББОУСЗ нь энэ хүчин зүйлийг шийдвэр гаргах үйл явцаас тусад нь үнэлэх шаардлагагүй гэж дүгнэсэн.

- (ж) **Иргэдийн эрх.** Зарим улс оронд иргэд нь шийдвэр гаргах үйл явцад оролцдог байж болох юм. Жишээлбэл; улсын секторын нэгдэл нь санал асуулгын замаар иргэдийн зөвшөөрлийг авах шаардлагатай байж болно. Нэгдлийг хүлээн зөвшөөрөх эсвэл татгалзах тэдгээр иргэдийн эрх нь уг нэгдлийн ангилалд хамааралтай гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Гэвч эдгээр эрх нь шийдвэр гаргах үйл явцад оролцох эрх юм гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс УСНББОУСЗ нь энэ хүчин зүйлийг шийдвэр гаргах үйл явцаас тусад нь үнэлэх шаардлагагүй гэж дүгнэсэн.

ДҮ31. Улсын секторын нэгдлийн хувьд хяналтын талаархи ойлголт ухагдахууныг нэмж гүйцээхэд дараах хүчин зүйлс ач холбогдолтой гэж УСНББОУСЗ үзээгүй:

- (а) **Секторын өөрчлөлт.** Секторын өөрчлөлт нь тухайн улсын секторын байгууллага үйл ажиллагааг худалдан авч буйг илэрхийлэх үзүүлэлт болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Гэвч энэхүү секторын өөрчлөлт нь харгалзан үзэх тусдаа хүчин зүйл биш, харин хяналтын өөрчлөлтийн үр дагавар гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Засгийн газрын нэгжүүдэд хамаарах тэдгээрийн эдийн засгийн шинж төрөлд үндэслэн институцийн нэгжүүдийг секторуудад ангилал ангилал нь ЗГСС-ийн шинж бөгөөд УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлд үүнтэй адилтгах заалт байхгүй гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Энэ нь макро эдийн засгийн статистикийн тайлагнал ба нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын хоорондох гол зөрүү хэвээр байх юм. Иймээс секторын өөрчлөлтийг УСНББОУСЗ нь улсын секторын нэгдлийг ангилал ач холбогдолтой хүчин зүйл гэж үзээгүй.
- (б) **Улс орны шинж төрөл.** Засгийн газрын янз бүрийн түвшнүүдийн хооронд ихээхэн харилцан үйлчлэлтэй буюу дахин хуваарилалт хийдэг улс орнуудын хувьд улсын секторын нэгдлийг нэг “бүлэг” мэт харагддаг байгууллагын хэсэг болох үйл ажиллагаа гэж үзэж болно хэмээн ЗББ-т ирүүлсэн зарим хариултанд дурдсан байсан. Ийм үзэл бодол нь улсын секторын нэгдлийн ангилалд нөлөөлж болох юм. Тайлагнагч байгууллагын байр сууринаас харвал, улс орны шинж төрөл нь улсын секторын нэгдлийн ангилалд хамааралтай

гэж УСНББОУСЗ үзэхгүй байна. Тайлагнагч байгууллага нь бүлэг мэт харагддаг байгууллагыг харгалзан лавлагаа болгохгүйгээр хяналт, төлбөр, шийдвэр гаргалт зэрэгт үнэлгээ өгөх боломжтой юм. Улс орны шинж төрөл нь улсын секторын нэгдлийн шинж чанарын үнэлгээний нэг хэсгийг бүрдүүлж болох бөгөөд бусад бүх хүчин зүйлсийн шинжилгээ нь дүгнэлтийн бус шинжтэй үр дүнг гаргасан буюу улсын секторын нэгдлийн тохиромжтой ангиллыг тодорхойлох хангалттай нотолгоо бүрдүүлдэггүй тохиолдолд байгууллага нь үүнийг харгалзан үзэх шаардлагатай байж болох юм гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн.

(в) **Засгийн газрын үйл ажиллагаа.** ЗББ-т хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь улсын секторын нэгдлийн ангилалд засгийн газрын үйл ажиллагаа хамааралтай гэсэн санал гаргасан. Тэдний гаргасан жишээнд дараах зүйлс хамаарна:

- (i) Засгийн газрын бодлогын зорилтуудад хүрэхийн тулд байгууллагын удирдах зөвлөлийг удирдан чиглүүлэх боломжийг засгийн газарт олгох яамны буюу засгийн газрын бусад бүрэн эрхийн оршин байдал;
- (ii) Үйл ажиллагааны төсвийн хувьд яамны зөвшөөрлийг шаардах;
- (iii) Одоогийн хууль тогтоомжийн дагуу засгийн газар нь тухайн байгууллагын удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийг томилох эсвэл чөлөөлөх өргөн эрх мэдэлтэй байдаг.

Дээрх жишээнүүд нь бие даасан хүчин зүйлсийг санал болгохоос илүүтэйгээр хяналтын буюу ерөнхий хяналтын үзүүлэлтүүд гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс засгийн газрын үйл ажиллагаа нь улсын секторын нэгдлүүдийн ангилалд хамааралтай гэж УСНББОУСЗ үзээгүй.

(г) **Байгууллага нь төрийн бодлогыг удирдан чиглүүлэх ба/буюу улсын хөрөнгөөр үндсэндээ санхүүжүүлдэг зах зээлийн бус үйл ажиллагааг эрхлэн явуулдаг.** Байгууллага нь төрийн бодлогыг удирдан чиглүүлэх ба/буюу улсын хөрөнгөөр үндсэндээ санхүүжүүлдэг зах зээлийн бус үйл ажиллагааг эрхлэн явуулдаг эсэхийг харгалзснаар хяналтыг дэмжин гүйцээх хэрэгтэй гэж ЗББ-т хариулт ирүүлсэн зарим хүмүүс үзэж байсан. Хэрэв ийм тохиолдол үүсвэл энэ нь нийлүүлэлтийг илэрхийлнэ. Энэхүү арга хандлага нь УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлд шинэ ойлголт ухагдахуун нэвтрүүлэхийг шаардана гэж УСНББОУСЗ тэмдэглэсэн. Жишээлбэл; зах зээлийн бус үйл ажиллагаа нь ЗГСС-ийн ойлголт ухагдахуун бөгөөд үүнийг УСНББОУСЗ хэрэглэдэггүй. УСНББОУСЗ нь ийм ойлголт ухагдахууныг СТ 60-д тусган оруулах нь тохиромжтой гэж үзээгүй. Иймээс энэхүү хүчин зүйлийг УСНББОУСЗ нь улсын секторын нэгдлийн ангилалд хамааралтай гэж үзээгүй.

- (д) **Хариуцлага.** Улсын секторын нэгдлийг бодит үнэ цэнээр тайлагнах нь уг нэгдлийн үр нөлөөний талаар илүү их мэдээллээр хангадаг боловч энэ нь нэгтгэх шийдвэрийг тухайн байгууллага хариуцах тохиолдолд зөвхөн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор ач холбогдолтой гэдгийг санал өгсөн зарим хүмүүс илэрхийлсэн. УСНББОУСЗ нь хариуцлагатай байдлыг өөрийн эрхийн хүрээнд анхдагч хүчин зүйл гэж үздэггүй боловч улсын секторын нэгдлийн ангиллын үр дүн болох мэдээлэл нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангавал зохино гэж мэдэгдсэн. Төлбөрийн болон шийдвэр гаргах үйл явцын шинжилгээ нь дүгнэлтийн бус шинжтэй үр дүнг гаргадаг буюу улсын секторын нэгдлийн тохиромжтой ангиллын хувьд хангалттай нотолгоог бүрдүүлдэггүй хэвийн бус гажих нөхцөлд байгууллага нь бусад асуудлуудыг, үүн дотроо ямар мэдээлэл нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлж, чанарын шинжүүд (ЧШ)-ийг хангах эсэхийг харгалзан үзэх шаардлагатай байж болно.
- ДҮ32. Иймээс УСНББОУСЗ нь төлбөр шилжүүлсэн эсэх, төлбөртэй эсвэл төлбөргүй байгаагийн учир шалтгаан ба шийдвэр гаргах үйл явц гэсэн хоёр нэмэлт хүчин зүйлсээр хяналтыг дэмжин гүйцээх хэрэгтэй гэж дүгнэсэн. Эдгээр хүчин зүйлс нь өргөн хүрээтэй бөгөөд дээр дурдсанчлан, бусад хүчин зүйлсийн элементүүдийг агуулсан байдаг.
- ДҮ33. УСНББОУС 35-д заасан хяналтын үзүүлэлтүүдийг дэмжин гүйцээх эсвэл улсын секторын нэгдлийг ангилах хяналтын ойлголт ухагдахууныг дэмжин гүйцээхэд эдгээр хүчин зүйлсийг ашиглаж болно гэж УСНББОУСЗ тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь эдгээр хоёр арга хандлагын ач холбогдлын хувьд шүүмжлэлтэй ханддаг. Хяналтын үзүүлэлтүүдийг дэмжин гүйцээхийн тулд эдгээр хүчин зүйлсийг ашиглах нь зэрэгцүүлэгдэх чанарын шинжийг илүү сайн хангах ангиллын арга хандлага бий болгох магадлалтай юм гэж УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Харин хяналтын ойлголт ухагдахууныг дэмжин гүйцээхийн тулд эдгээр хүчин зүйлсийг ашиглах нь илүү хамааралтай ба үнэн зөв толилуулгын мэдээллээр хангах магадлалтай гэж УСНББОУСЗ үзсэн. Хяналтын ойлголт ухагдахууныг дэмжин гүйцээх хүчин зүйлсийг ашиглах нь хариулт өгсөн хүмүүсийн санал болгосон асуудлуудыг мөн харгалзан тусгах илүү их магадлалтай байдаг.
- ДҮ34. ЗББ-т хариулт өгсөн хүмүүс нь хяналтын үзүүлэлтүүдийн цаашдын хөгжүүлэлтээр бүрэн тусгах магадлал багатай хяналтанд зөвхөн үндэслэн худалдан авалт ба нийлүүлэлтийг өөр хооронд ялгаж салгахад хүндрэлтэй гэж үзсэн. Нэгдлийн оролцогч нэг тал үйл ажиллагааны хяналтыг олж авах нь худалдан авалтын чухал элемент мөн боловч энэ нь тухайн нэгдлийг худалдан авалт эсэхийг тодорхойлоход дангаараа хангалтгүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн ба ингэж дүгнэсэн. Иймээс УСНББОУСЗ нь улсын секторын нэгдлийг дараах байдлаар ангилах арга хандлага боловсруулахыг хүлээн зөвшөөрсөн:

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (а) Хяналтын ойлголт ухагдахууныг дэмжин гүйцээх хүчин зүйлсийг ашигласнаар; ба
  - (б) Нэгдлийн оролцогч нэг тал нь тухайн нэгдлийн үр дүнд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авах эсэх хүрээнд хяналтыг харгалзсан үзсэнээр.
- ДҮ35. Хяналтыг дэмжин гүйцээхдээ хүчин зүйлсийг ашиглах арга хандлага боловсруулахыг хүлээн зөвшөөрснөөр УСНББОУСЗ нь улсын секторын нэгдлийг ангилах үедээ хяналтанд болон бусад хүчин зүйлсэд өгөх харгалзах ач холбогдлыг авч хэлэлцсэн. Энэхүү хэлэлцүүлгийн нэг хэсэг болгон УСНББОУСЗ нь дараах хоёр хандлагыг тодорхойлсон:
- (а) Няцааж болох урьдчилсан нөхцлийн хандлага. Нэгдлийн оролцогч нэг тал нь үйл ажиллагааны хяналтыг олж авсан тохиолдолд энэхүү хандлагын дагуу тухайн нэгдэл нь худалдан авалт гэсэн няцааж болох урьдчилсан нөхцөл үүсдэг. Энэхүү хандлага нь хяналт олж авахад ихээхэн ач холбогдол өгдөг бөгөөд бусад хүчин зүйлсийн шинжилгээ нь энэхүү урьдчилсан нөхцлийг няцаах хангалттай нотолгоо байгаа эсэхэд чиглэгддэг.
  - (б) Тус тусад нь жин өгөх хандлага. Энэхүү хандлагын дагуу, хяналт олж авалт, төлбөр төлөлт, шийдвэр гаргалтанд өгөх жин буюу ач холбогдол нь тухайн нэгдлийн бие даасан нөхцөл байдлуудад үндэслэсэн мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал болдог. Тайлан бэлтгэгч нар нь (хэрэв байгаа бол) ямар хүчин зүйлс худалдан авалтыг, харин (хэрэв байгаа бол) ямар хүчин зүйлс нийлүүлэлтийг заан илэрхийлж буй эсэхийг тодорхойлдог. Худалдан авалтын болон нийлүүлэлтийн аль алины шинж тэмдэг байгаа бол тайлан бэлтгэгч нь өөрийн мэргэжлийн шүүн тунгаалтыг ашиглан тэдгээр харгалзах хүчин зүйлс бүрд өгсөн жин буюу ач холбогдол нь тухайн ангиллыг тодорхойлдог.
- ДҮ36. Няцааж болох урьдчилсан нөхцлийн хандлага нь нөхцөл байдлыг илүү тодорхой болгож, зэрэгцүүлэгдэх чанарын шинжүүдийг илүү сайн хангадаг гэж УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Тус тусад нь жин өгөх хандлага нь практикт арай илүү субъектив байх магадлалтай юм. Гэвч тус тусад нь жин өгөх хандлага нь тухайн нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг илүү сайн тусгах боломжийг практик ажилтнуудад олгодог бөгөөд хамааралтай байх, үнэн зөв толилуулах гэсэн чанарын шинжүүдийг илүү сайн хангаж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ37. Ангиллыг тодорхойлоход хяналт нь бусад хүчин зүйлсээс илүү ач холбогдолтой бөгөөд няцааж болох урьдчилсан нөхцлийн хандлага нь үүнийг тусгадаг гэж ихэнх гишүүд үзэж байсан. Иймээс УСНББОУСЗ нь няцааж болох урьдчилсан нөхцлийн хандлагыг хөгжүүлэн боловсруулахыг зөвшөөрсөн.
- ДҮ38. Нэгдлийн оролцогч нэг тал тэдгээр үйл ажиллагаануудын хяналтыг олж авснаар худалдан авалт үүсэхэд хүргэнэ (энэ нь хамааралтай байх ба

үнэн зөв толилуулах гэсэн чанарын шинжүүдийг орхигдуулж, харин зэрэгцүүлэгдэх байдал гэсэн чанарын шинжийг илүү сайн хангадаг) гэсэн няцааж болох урьдчилсан нөхцлийг харгалзахын хамтаар хяналтын гүйцээлт болгон бусад хүчин зүйлсийг (энэ нь зэрэгцүүлэгдэх байдлыг орхигдуулж, харин хамааралтай байх ба үнэн зөв толилуулах гэсэн чанарын шинжүүдийг илүү сайн хангадаг) мөн харгалзан үздэг тийм хандлага нь чанарын шинжүүдийн зохих тэнцвэрийг бий болгох магадлалтай гэдгийг УСНББОУСЗ нь энэхүү шийдвэрийг гаргах үедээ тэмдэглэсэн.

ДҮ39. Нэгдлийн ангилал нь уг нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг тусган илэрхийлэхгүй боловч улсын секторын нэгдэл нь худалдан авалт гэсэн урьдчилсан нөхцлийг төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд эсвэл шийдвэр гаргалттай холбоотой үзүүлэлтүүд няцаахад цөөн ховор тохиолдолд хангалттай бус байх тийм боломжит байдлыг УСНББОУСЗ мөн харгалзан үзсэн. Уг урьдчилсан нөхцөл няцаагдах эсэхийг тодорхойлохдоо тухайн нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэх шаардлагатай гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Ингэж тодорхойлоход нь тайлан бэлтгэгч нарт туслахын тулд ийм цөөн ховор тохиолдолд ч гэсэн аль ангилал нь санхүүгийн тайлагналын зорилтууд болон чанарын шинжүүдийг хамгийн сайнаар хангах мэдээлэл бүрдүүлж буй эсэхийг үнэлгээ хийхийг СТ 60-д мөн шаардсан байдаг.

ДҮ40. Улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж үзэх хамгийн нийтлэг тохиолдлууд дараах байдалтай байна гэж УСНББОУСЗ дүгнэсэн:

- (а) Нэгдлийн оролцогч нэг тал нь үйл ажиллагааны хяналтыг олж авах ба уг шилжүүлсэн үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй байсан талуудад ийм эрхээ өгсөний хариуд нөхөн төлбөр болгон төлбөр төлдөг.
- (б) Нэгдлийн оролцогч нэг тал нь уг шилжүүлсэн үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй байсан талуудад нөхөн төлбөр болгон төлбөр төлөхгүйгээр тухайн улсын секторт хамааралгүй үйл ажиллагааны хяналтыг олж авдаг.
- (в) Нэгдлийн оролцогч нэг тал нь бусад талуудад уг нэгдлийг тулган хүлээлгэснээр тухайн улсын секторт хамааралгүй үйл ажиллагааны хяналтыг олж авдаг.
- (г) Нэгдлийн оролцогч нэг тал нь өөр тусдаа засгийн газраас тухайн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг.

Хэвийн бус гажих нөхцлөөс бусад тохиолдолд СТ 60-д тусгасан, ангиллын хандлага нь ийм нэгдлийг худалдан авалт байдлаар ангилахад хүргэнэ гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Энэ нь тухайн хэрэглэсэн арга тохиромжтой гэсэн баталгааг УСНББОУСЗ-д дахин олгодог.

*СТ 60-д өгсөн хариултууд*

- ДҮ41. УСНББОУСЗ нь СТ 60-д өгсөн хариултуудыг авч үзсэн. Улсын секторын нэгдлийг ангилах уг СТ-д тусгасан ерөнхий хандлагыг ихээхэн дэмжиж байгааг УСНББОУСЗ тэмдэглэсэн.
- ДҮ42. Гэхдээ хариулт ирүүлсэн хүмүүс нь уг арга хандлагыг сайжруулах боломжтой гэж үзсэн ба тийм талбаруудыг тодорхойлсон. Тодорхойлсон гол асуудлууд нь дараах байдалтай байна:
- (а) Эргэлзэж тээнгэлзэхээс илүүтэйгээр байнга мэдэгдэхүйц хэмжээгээр няцаагдахаар хүлээгдэж буй тийм няцааж болох урьдчилсан нөхцөлтэй байх;
  - (б) Нэгдлийн оролцогч нэг тал нь үйл ажиллагааны хяналтыг олж авсан ихэнх тохиолдолд худалдан авалтын арга ашиглахыг энэ СТ шаарддаг байдлаар зарим оролцогч талууд үүнийг тайлбарласнаар уг хандлага нь хяналтанд хэт их ач холбогдол өгдөг мэтээр харагддаг; ба
  - (в) Нэгдлийн оролцогч нэг тал нь үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэхийг лавлагаа болгон харгалзахын оронд холбогдох үзүүлэлтүүд (төлбөр, шийдвэр гаргалт)-ийг лавлагаа болгосноор олон улс орны хувьд улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг тодорхойлоход илүү хялбар байдаг.
- ДҮ43. УСНББОУСЗ нь дээрх асуудлуудыг анхааран үзсэн. Няцааж болох урьдчилсан нөхцөл нь хааяа нэг няцаагдана гэж ерөнхийдөө үздэг бөгөөд байнга няцаана гэсэн хүлээлттэйгээр энэ нэр томъёог ашиглах нь тайлан бэлтгэгч нарыг төөрөгдөлд хүргэж болох юм гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. УСНББОУСЗ-ийн санаа зорилгын дагуу тухайн нэг нэгдэл нь худалдан авалт биш байх тохиолдолд ийм төөрөгдлийн улмаас тайлан бэлтгэгч нь тэрхүү улсын секторын нэгдлийн худалдан авалт гэж ангилахад хүргэж болох юм.
- ДҮ44. Няцааж болох урьдчилсан нөхцлийг хэрхэн ойлгож тайлбарлах талаархи ийм боломжит төөрөгдөл нь зарим оролцогч талууд худалдан авалтын аргыг зохисгүй хэрэглэдэг уг асуудлын тайлбар байж болох юм гэж УСНББОУСЗ дүгнэсэн. СТ-д тусгасан арга хандлага нь нэгдлийн оролцогч нэг тал үйл ажиллагааны хяналтыг олж авсан ихэнх тохиолдолд худалдан авалтын арга ашиглахыг шаардана гэсэн санааг УСНББОУСЗ илэрхийлээгүй. Худалдан авалт нь хязгаарлагдмал нөхцөл байдалд үүсдэг бөгөөд үүнийг дээрх ДҮ40-р параграф дахь жагсаалтаас харж болно гэж УСНББОУСЗ үзсэн.
- ДҮ45. Олон улс орны хувьд үзүүлэлтүүдийг харгалзсанаар, ялангуяа нэгдэл нь ерөнхий хяналтан дор хийгдсэн эсэхийг харгалзан үзэх замаар улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг шууд тодорхойлж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Гэвч бүх улс орны хувьд ийм байхгүй гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Хяналт нь гол чухал хүчин зүйл хэвээр байна гэдгийг УСНББОУСЗ онцлон дурдсан: тухайлбал;

нэгдлийн оролцогч нэг тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг зөвхөн тийм тохиолдолд худалдан авалт үүсдэг. СТ 60-д дурдсан, арга хандлага нь холбогдох бүх хүчин зүйлсийг харгалзан үзсэн гэдгийг ханган магадлах зохих шийдвэрийн хүрээг тогтоодог гэдгийг УСНББОУСЗ мөн тэмдэглэсэн.

ДҮ46. Иймээс УСНББОУСЗ нь уг ангиллын арга хандлагын мөн чанарыг өөрчлөхгүйгээр эдгээр асуудлуудыг харгалзан тусгахын тулд энэхүү хандлагыг илэрхийлэх арга замыг дахин авч үзэхийг зөвшөөрсөн. Няцааж болох урьдчилсан нөхцөл ба хяналтын талаархи лавлагаа нь нэгдлийн эдийн засгийн мөн чанарт үндэслэн ангиллыг тодорхойлох үйл явцын эхний алхам болох юм. Энэхүү эхний алхамыг хийх үедээ УСНББОУСЗ нь аль нэг тал хяналтыг олж авсан гэдгийг тогтоомогц тухайн нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг тодорхойлоход төлбөр болон шийдвэр гаргалтаас илүү их ач холбогдлыг хяналтанд өгөх хэрэгтэй гэсэн санаа илэрхийлээгүй. Хяналт олж авалтанд илүү их ач холбогдол өгөх арга хандлагын талаархи ДҮ35(а) параграф дахь заалт нь будлиан үүсэхэд хүргэж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Хяналт байхгүй бол худалдан авалтын боломжит байдлыг үгүйсгэх тул хяналт нь чухал хэвээр байна, гэвч нэг тал нь хяналтыг олж авсан нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг тодорхойлоход түүний үзүүлэх ач холбогдол нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал байдаг. СТ 60-д тусгасан, ангиллын арга хандлага нь зохистой бөгөөд энэ Стандартад оруулсан өөрчлөлтүүд нь уг арга хандлагыг хэрхэн ашиглахыг илүү ойлгомжтой болгох зорилготой гэсэн УСНББОУСЗ-ийн байр суурь хэвээр байсан. Эдгээр өөрчлөлтүүд нь СТ 60-аас өөр ангиллыг тогтоох санаа зорилгогүй юм.

### *СТОУС 3-тай харьцуулалт*

ДҮ47. Энэ Стандарт нь СТОУС 3-тай бүрэн нийдэггүй. СТОУС 3 нь бүх бизнесийн нэгдлийг худалдан авалт гэж үздэг бол энэ Стандарт нь нийлүүлэлт ба худалдан авалтын аль алиныг тусгасан байдаг. Дараах шалтгааны улмаас ийм зөрүүтэй байх нь зохистой гэж УСНББОУСЗ үзсэн:

- (а) Нэгдэгч аж ахуйн нэгжүүдийн аль нь ч бусаддаа хяналт тавьдаггүй “жинхэнэ нэгдэл” буюу “хувь оролцооны адил тэнцүү нэгдэл” нь маш ховор бөгөөд үнэндээ огт байдаггүй гэж НББОУСЗ нь СТОУС 3-ыг боловсруулж байх үедээ дүгнэсэн байдаг. Харин улсын секторт ийм нэгдэл түгээмэл байдаг. Нийлүүлэлтийг авч үздэггүй Стандарт боловсруулах нь улсын секторын НЗСТ-гийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй юм.
- (б) СТОУС 3-ыг мөрддөг бизнесүүд нь ямагт эзэдтэй байх учраас нэгтгэгчийг тодорхойлох боломж үргэлж байдаг гэж СТОУС 3-д төсөөлдөг. Харин улсын секторын хувьд, улсын секторын байгууллага дахь тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоогүй байж болох учраас энэ нь нэгтгэгчийг тодорхойлох боломжгүй болгодог. Ийм нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрдөггүй



Стандарт боловсруулах нь улсын секторын НЗСТ-гийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй юм.

**Нийлүүлэлтийн тайлагнал (15-57-р параграф)**

*Нийлүүлэлтийг тайлагнах Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг мөрдөх шалтгаан*

ДҮ48. ЗББ-ийг боловсруулах үедээ УСНББОУСЗ нь улсын секторын нэгдлийг тайлагнах гурван аргыг тодорхойлсон бөгөөд эдгээрийн аль алиныг практикт мөрдөж эсвэл авч хэлэлцэж болох юм. Үүнд:

- (а) Худалдан авалтын арга;
- (б) Хувь оролцоо нэгтгэх арга, үүн дотроо энэ аргын боломжит сайжруулалт; ба
- (в) Шинэ эхлэлийн арга.

ДҮ49. Худалдан авалтын арга (СТОУС 3-д мөрддөг) нь бүх нэгдлийн хувьд нэгтгэгчийг тодорхойлохыг шаарддаг. УСНББОУСЗ нь улсын секторын бүх нэгдлийн хувьд нэгтгэгчийг тодорхойлох боломжгүй байж болох бөгөөд нэгтгэгчийг тодорхойлох боломжгүй аливаа нэгдлийг нийлүүлэлт байдлаар ангилна гэж нэгэнт дүгнэсэн. Иймээс худалдан авалтын тайлагналын арга нь нийлүүлэлтийн хувьд тохиромжтой биш гэж УСНББОУС дүгнэсэн.

ДҮ50. Хувь оролцоогоо нэгтгэх нягтлан бодох бүртгэлийн аргыг НББОУС 22, *Бизнесийн Нэгдэл* (СТОУС 3-ын өмнөх стандарт)-т өмнө нь ашигладаг байсан. Нэгтгэгчийг тодорхойлох боломжгүй нэгдлийн хувьд үүнийг мөрдөх зориулалттай байсан. Хувь оролцоогоо нэгтгэх нягтлан бодох бүртгэлийн аргыг олон улс орнууд өмнө нь нэгдлийн болон нийлүүлэлтийн нягтлан бодох бүртгэлийн суурь болгон ашигладаг байсан. Олон байгууллагууд нь ерөнхий хяналтанд буй нэгдлийг тайлагнахдаа үүнийг үргэлжлүүлэн ашиглаж байна (энэ нь СТОУС 3-ын цар хүрээнд хамаарахгүй юм).

ДҮ51. Нэгдэгч үйл ажиллагаануудыг одоо хамтран өмчилж, удирдаж байгаа боловч хувь оролцоогоо нэгтгэх арга нь тэдгээрийг урьдын адил үргэлжлүүлэн ажиллаж байгаа мэтээр тайлагнадаг. Нэгдэл хийгдсэн тайлант үеийн болон тодруулсан аливаа зэрэгцүүлэгдэх тайлант үеүдийн санхүүгийн тайлангийн зүйлсийг хэрэв тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудыг уг толилуулсан хамгийн эхний тайлант үеийн эхнээс нэгтгэсэн бол тайлагнах байсан тийм байдлаар тэрхүү үр дүнгийн байгууллагын санхүүгийн тайланд тусгана. Өөрөөр хэлбэл, хүлээн зөвшөөрөлтийн цэг нь толилуулсан хамгийн эхний тайлант үеийн эхлэл байх бөгөөд иймээс зэрэгцүүлэх мэдээллийг дахин илэрхийлнэ.

ДҮ52. Зэрэгцүүлэх мэдээллийг дахин тайлагнах шаардлага нь алдаатай бөгөөд шаардлагагүй байж болох юм гэж зарим хүмүүс үздэг болохыг УСНББОУСЗ тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь хувь оролцоогоо нэгтгэх

нягтлан бодох бүртгэлийн аргын хувилбарыг ЗББ-т авч хэлэлцсэн бөгөөд үүнийг хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга гэж нэрлэсэн. Үр дүнгийн байгууллага нь санхүүгийн байдлын тайлан дахь зүйлсийг уг нийлүүлэлтийн өдрөөр хувь оролцоогоо нэгтгэх нягтлан бодох бүртгэлийн аргын дагуу нэгтгэдэг.

- ДҮ53. ЗББ-т УСНББОУСЗ-ийн авч хэлэлцсэн гурав дахь арга нь нягтлан бодох бүртгэлийн шинэ эхлэлийн арга юм. Хувь оролцоогоо нэгтгэх нягтлан бодох бүртгэлийн аргатай харьцуулахад энэхүү шинэ эхлэлийн аргын урьдчилсан нөхцөл бол уг үр дүнгийн байгууллага нь шинэ байгууллага (шинэ байгууллага үүсгэн байгуулсан эсэхээс үл хамааран) байх явдал бөгөөд иймээс түүний түүх нь тэрхүү өдрөөс эхлэх юм. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга нь практикт ижил үр нөлөөтэй байдаг.
- ДҮ54. Шинэ эхлэлийн арга нь нэгдэгч бүх үйл ажиллагаануудын тодорхойлогдох бүх хөрөнгө, өр төлбөрийг уг үр дүнгийн байгууллагын санхүүгийн тайланд тэрхүү нэгдлийн өдөр бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Үүнд: уг нэгдэгч үйл ажиллагаануудын өмнө хүлээн зөвшөөрөөгүй байсан тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт хамаарна. Өөрөөр хэлбэл, шинэ эхлэлийн арга нь худалдан авалтын аргатай ижил хүлээн зөвшөөрөлтийн болон хэмжилтийн суурийг ашигладаг боловч үүнийг зөвхөн тухайн нэгдэгч үйл ажиллагаанд бус, харин нэгдэгч бүх үйл ажиллагаануудад хэрэглэдэг.
- ДҮ55. Хувь оролцоогоо нэгтгэх нягтлан бодох бүртгэлийн арга, хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга, нягтлан бодох бүртгэлийн шинэ эхлэлийн арга нь бүгдээрээ нийлүүлэлтийг тайлагнах боломжит суурийг бүрдүүлдэг гэсэн дүгнэлтэнд УСНББОУСЗ нь ЗББ-ийг боловсруулах үедээ хүрсэн.
- ДҮ56. Үр дүнгийн байгууллагын ирээдүйн мөнгөн гүйлгээ болон үйлчилгээний чадавхи нь нийлүүлэлтийг тайлагнахдаа ямар арга ашигласан эсэхээс үл хамааран ерөнхийдөө ижил байдаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Гэвч үр дүнгийн байгууллагын санхүүгийн үр дүнгийн болон санхүүгийн байдлын толилуулга нь тухайн хэрэглэсэн аргаас хамааран мэдэгдэхүйц өөр байдаг. Аль аргыг хэрэглэхээ тухайн тайлан бэлтгэгч нар сонгох боломж олговол байгууллагуудын хоорондох болон цаг хугацааны хоорондох зэрэгцүүлэгдэх байдлыг бууруулах юм.
- ДҮ57. Нийлүүлэлтийг тайлагнах хувь оролцоогоо нэгтгэх арга буюу хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан аргыг дэмжигчид нь хэрэглэгчдийн дараах мэдээллийн хэрэгцээг эдгээр аргууд хангадаг гэж үздэг:
- (а) Шийдвэр гаргах зорилго бүхий мэдээллийн хувьд; ба
  - (б) Нөөцийн ашиглалтын талаархи уг үр дүнгийн байгууллагын хариуцлагыг үнэлэх.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

Яагаад гэвэл, улсын секторын байгууллагуудын НЗСТ-гийн хэрэглэгчид нь санхүүгийн нөөцийг хэрхэн хуваарилсаныг болон тухайн байгууллагын санхүүгийн байдлыг үнэлэхдээ уг мэдээллийг ашигладаг. Хувь оролцоогоо нэгтгэх нягтлан бодох бүртгэлийн арга эсвэл хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг ашигласнаар ийм мэдээллийг олж авч болно.

- ДҮ58. Эдгээр аргууд нь уг нэгдэгч үйл ажиллагаануудын нийлүүлэлтээс өмнөх санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнг тусгадаг учраас хамааралтай байх, үнэн зөв толилуулах гэсэн чанарын шинжүүдийг эдгээр аргууд хангаж байна гэж үздэг. Үр дүнгийн байгууллагын дараагийн тайлант үеийн гүйцэтгэл болон тэдгээр нөөцийн удирдлагын талаар түүний хүлээх хариуцлагыг уг нийлүүлэлтээс өмнө хариуцлагыг үнэлэхдээ ашиглаж байсантай ижил сууриар үнэлж болно.
- ДҮ59. Хувь оролцоогоо нэгтгэх нягтлан бодох бүртгэлийн арга буюу хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг хэрэглэхэд ерөнхийдөө хамгийн бага өртөг зардалтай гэж үздэг. Яагаад гэвэл, эдгээр нь:
- (а) Уг нэгдэгч үйл ажиллагаануудын хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн одоогийн дансны үнийг ашигладаг; ба
  - (б) Нийлүүлэлтээс өмнө хүлээн зөвшөөрөөгүй байсан хөрөнгө, өр төлбөрийг тодорхойлох, хэмжих, хүлээн зөвшөөрөхийг шаарддаггүй.
- ДҮ60. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга нь нийлүүлэлтийг түүний бодитой байгаагаар харуулдаг учраас уг аргыг дэмжигчид нь хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг хамгийн тохиромжтой гэж үздэг. Яагаад гэвэл, энэ арга нь нэгдэгч үйл ажиллагаануудын хөрөнгө, өр төлбөрийг уг нийлүүлэлтийн өдрөөр хүлээн зөвшөөрдөг. Ингэснээр нийлүүлэлтийн үнэн зөв толилуулга болно гэж уг аргыг дэмжигчид үздэг.
- ДҮ61. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга хэрэглэхийг дэмжигчид нь тухайн үр дүнгийн байгууллагын гүйцэтгэлийг үнэлэхэд тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын түүх туслаж болох юм гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Түүхэн мэдээллийн талаархи хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэхгүйгээр хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг ашиглах нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахгүй байж болох юм гэдгийг УСНББОУСЗ нь янз бүрийн аргуудын ач холбогдлыг шүүмжлэн хэлэлцэх үедээ тэмдэглэсэн.
- ДҮ62. Үр дүнгийн байгууллага нь нэгдэгч үйл ажиллагаануудын нөөцийн одоогийн үнэ цэнийн талаар хариуцлага хүлээдэг тул нягтлан бодох бүртгэлийн шинэ эхлэлийн арга нь хувь оролцоогоо нэгтгэх нягтлан бодох бүртгэлийн арга болон түүний сайжруулсан хувилбарын аль алианаас онолын хувьд давуутай гэж зарим хүмүүс үздэг. Энэ арга нь

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

нэгдэгч үйл ажиллагаануудын тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийг уг нийлүүлэлтээс өмнө хүлээн зөвшөөрч байсан эсэхээс үл хамааран хүлээн зөвшөөрдөг тул нийлүүлэлтийн талаар илүү бүрэн цогц мэдээллээр бас хангадаг.

ДҮ63. Нягтлан бодох бүртгэлийн шинэ эхлэлийн аргыг дэмжигчид нь хэрэглэгчдийн дараах хэрэгцээ шаардлагыг уг арга хангадаг гэж үздэг:

(а) Шийдвэр гаргах зорилго бүхий мэдээллийн хувьд; ба

(б) Үр дүнгийн байгууллагын нөөцийн ашиглалтын талаархи хариуцлагыг үнэлэх.

Яагаад гэвэл, энэ арга нь тухайн байгууллагын санхүүгийн байдал, түүнчлэн санхүүгийн нөөцийг хэрхэн хуваарилсан эсэхийг илүү сайн үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог.

ДҮ64. Нягтлан бодох бүртгэлийн шинэ эхлэлийн арга нь өргөн утгаараа, худалдан авалтын тайлагналын аргад бодит үнэ цэнийг ашиглах өргөжүүлсэн хэлбэр гэж энэ аргыг дэмжигчид үздэг. Иймээс худалдан авалтын хувьд хэрэв худалдан авалтын аргыг мөрддөг бол нийлүүлэлтэнд үүнтэй адилтгах нягтлан бодох бүртгэлийн аргыг мөрдөхгүй байх шалтгаан үгүй гэж тэд үздэг.

ДҮ65. Үр дүнгийн байгууллага нь өөрийн хөрөнгө, өр төлбөрийг дахин хэмжээгүй боловч түүний гүйцэтгэл ба хариуцлагыг хэрэглэгч нар үнэлэх боломжтой байдаг учраас хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг мөрдөхөд тохиромжтой гэсэн дүгнэлтэнд УСНББОУСЗ нь уг ЗББ-ийг боловсруулах үедээ хүрсэн. Түүнчлэн, энэ нь нийлүүлэлтийг түүний хийгдсэн өдөр хүлээн зөвшөөрдөг. Энэ арга нь хэрэглэгчдэд илүү хамааралтай мэдээллээр хангана гэж үр дүнгийн байгууллага үзэж байгаа бол анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр дахин үнэлэхийг УСНББОУСЗ зөвшөөрдөг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн.

ДҮ66. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга нь нийлүүлэлтийн хувьд мөрдөхөд тохиромжтой арга гэсэн УСНББОУСЗ-ийн байр суурийг уг ЗББ-т хариу ирүүлсэн хүмүүс ерөнхийдөө дэмжсэн. СТ 60-ыг боловсруулахдаа УСНББОУСЗ нь дээрх аргуудыг дахин авч үзсэн бөгөөд өөрийн өмнө илэрхийлсэн байр суурийг өөрчлөх учир шалтгаан байхгүй гэж тодорхойлсон. Иймээс СТ 60-д дурдсан, нийлүүлэлтийн хувьд УСНББОУСЗ нь хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг мөрдөх хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Улсын секторын байгууллагуудын НЗСТ-гийн хэрэглэгчид нь өөрт шаардлагатай түүхэн мэдээллээ олж авах боломжийг бүрдүүлэхийн тулд хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргад зохих тодруулгыг оруулах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ нь энэхүү шийдвэрийг гаргах үедээ хүлээн зөвшөөрсөн.

ДҮ67. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга нь нийлүүлэлтийн хувьд мөрдөхөд тохиромжтой арга гэдгийг СТ 60-д хариулт өгсөн хүмүүс ерөнхийдөө зөвшөөрсөн. Гэвч хувь оролцоогоо нэгтгэх нягтлан бодох бүртгэлийн арга нь илүү сайн мэдээллээр хангадаг гэж хариулт өгсөн зарим хүмүүс үзсэн бөгөөд хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн аргыг зөвхөн өртөг/үр өгөөжийн шалтгаанаар дэмжсэн байна. Зарим тохиолдолд өмнөх тайлант үеийн мэдээллээр хангасны үр өгөөж нь түүнийг бэлтгэх өртөг зардлаас илүү байдаг гэж эдгээр хариулт өгсөн хүмүүс үзсэн. УСНББОУСЗ нь энэхүү байр суурийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд өмнөх тайлант үеийн мэдээллийг толилуулахыг тухайн үр дүнгийн байгууллагад зөвшөөрөх боловч заавал шаардах хэрэггүй гэж үзсэн. УСНББОУСЗ нь өмнөх тайлант үеийн мэдээллийг дахин тайлагнах хэрэггүй гэж шийдвэрлэсэн, ингэж дахин тайлагнах нь хүлээн зөвшөөрөлтийн өөр цэг шаардах бөгөөд ингэснээр зэрэгцүүлэгдэх байдлыг бууруулах юм.

*Хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн өмнөх дансны үнээр хүлээн зөвшөөрч, хэмжих зарчмын гажих нөхцлүүд*

ДҮ68. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга нь нэгдэгч үйл ажиллагаануудын хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн өмнөх дансны үнээр хүлээн зөвшөөрч, хэмжихийг уг үр дүнгийн байгууллагаас шаарддаг бөгөөд тэрхүү үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд тэдгээр дансны үнэд тохируулга хийх шаардлагад захирагддаг. Нийлүүлэх өдрөөс өмнө эсвэл хойш хийгдсэн эсэхээс үл хамааран тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын хоорондох бүх ажил гүйлгээний үр нөлөөг тэрхүү үр дүнгийн байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэхдээ устгаж цэвэрлэнэ.

ДҮ69. УСНББОУСЗ нь эдгээр зарчмуудыг мөрдөхөд тохиромжгүй нөхцөл байдлуудыг авч үзсэн. УСНББОУСЗ нь хүлээн зөвшөөрөлтийн ба/буюу хэмжилтийн зарчмуудын гажих нөхцлийг хэрэглэхэд тохиромжтой гурван нөхцөл байдлыг тодорхойлсон:

- (а) **Нэгдэгч нэг үйл ажиллагаа нь нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө нь олгосон лиценз ба адилтгах эрхүүд.** Нэгдэгч нэг үйл ажиллагаанаас нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд лиценз буюу адилтгах эрхийг олгох ба хүлээн авагч нь түүнийг биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрч болох юм. Ерөнхий зарчмуудыг мөрдөх нь ийм ажил гүйлгээг устгаж цэвэрлэхийг шаарддаг. Гэхдээ лиценз буюу адилтгах эрх олголтын хувьд биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуур хангагддаг гэж УСНББОУСЗ үзсэн. Харин дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрдөггүй тохиолдолд хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг бий болгох тодорхойлогдох хөрөнгө байгаа эсэх, хэзээ байх эсэхийг тогтоох, тухайн хөрөнгийн өртгийг найдвартай тодорхойлох асуудлуудын улмаас ингэж устгаж цэвэрлэдэг. Лиценз буюу адилтгах эрхийг хүлээн авагчид олгомогц энэ нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний

чадавхи бий болгох тийм тодорхойлогдох хөрөнгө байгаа гэдгийг илэрхийлнэ. Үүнтэй адилаар тухайн ажил гүйлгээ нь хөрөнгийн өртгийг тогтоодог. Иймээс бие бус хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдана. Энэхүү шалтгааны улмаас лиценз буюу адилтгах эрхийг олгодог буюу хүлээн авдаг нэгдэгч үйл ажиллагаанууд нь нийлүүлэлтийн нэг хэсэг байх тохиолдолд уг хөрөнгийг устгаж цэвэрлэхгүй. Ийм нөхцөл байдал нь нэгдэгч нэг үйл ажиллагаанаас нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд биет хөрөнгийг борлуулсантай адил байх юм. Тухайн биет хөрөнгийг борлуулагч өмнө нь хүлээн зөвшөөрч байсан тул борлуулалтын үр нөлөөг устгаж цэвэрлэснээр тэрхүү биет хөрөнгийг өөрийг нь устгаж цэвэрлэхгүй юм. Лиценз буюу адилтгах эрхийн хувьд эрх олгогч нь уг биет бус хөрөнгийг өөрөө хүлээн зөвшөөрөх байсан, иймээс тухайн ажил гүйлгээ нь биет бус хөрөнгийн оршин байдлын талаар хангалттай нотолгоог бүрдүүлдэг тул тэрхүү ажил гүйлгээг устгаж цэвэрлэх нь биет бус хөрөнгийг өөрийг нь устгахгүй юм. Нэгдэгч үйл ажиллагаа нь бусад үйл ажиллагаануудын хяналтыг олж авдаг зарим тохиолдолд тухайн эрхийг дахин олж эзэмшсэн эрх байдлаар авч үзэж болохыг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Ингэснээр нягтлан бодох бүртгэлийн өөр арга хэрэглэнэ гэж УСНББОУСЗ үзэхгүй байгаа бөгөөд уг дахин олж эзэмшсэн эрхийг худалдан авалтын аргын дагуу биет бус хөрөнгө байдлаар хүлээн зөвшөөрнө гэж тэмдэглэсэн. Эдгээр учир шалтгааны улмаас УСНББОУСЗ нь нэгдэгч нэг үйл ажиллагаанаас нэгдэгч нөгөө үйл ажиллагаанд өмнө олгосон лиценз буюу адилтгах эрхийн хувьд хүлээн зөвшөөрсөн хөрөнгийг устгаж цэвэрлэх шаардлагагүй гэж дүгнэсэн.

- (б) **Орлогын албан татвар.** Улсын секторын хувьд нийлүүлэлт, ялангуяа дээд түвшний засгийн газрын байгууллагын тулган хүлээлгэсэн нийлүүлэлт нь түүний нөхцөл, болзлын нэг хэсэг байдлаар татварын чөлөөлөлтийг агуулсан байж болох юм. Үр дүнгийн байгууллага нь нийлүүлэлтээс өмнө оршин байсан бус, харин нийлүүлэлтээс хойш оршин байгаа аливаа татварын зүйлсийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. СТ 60-д хариулт өгсөн хүмүүсийн саналуудыг харгалзан үзсэнээр УСНББОУСЗ нь нийлүүлэлтийн нөхцөл, болзлын нэг хэсэг байдлаар биш, харин нийлүүлэлтийн дараагийн тайлант үед ямар нэг татварын чөлөөлөлт үүсэх тийм тохиолдол гарч болно гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Энэхүү хоёр тохиолдлын аль алиныг зохицуулах заалтыг УСНББОУС 40-д тусган оруулахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн.
- (в) **Ажилтны тэтгэмж.** Нийлүүлэлтээс хойш, ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөрийн хувьд УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ээр хүлээн зөвшөөрөхийг шаарддаг хөрөнгө, өр төлбөр нь нэгдэгч үйл ажиллагаануудын адилтгах дүнгүүдийн нэгтгэсэн дансны үнээс өөр байж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Жишээлбэл; нийлүүлэлт нь зөвхөн олон ажил олгогчийн тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн оролцогчид болох нэгдэгч таван үйл ажиллагааг хамардаг. Нийлүүлэлтээс өмнө, тэдгээр нэгдэгч үйл

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

ажиллагаанууд нь уг тогтоосон тэтгэмжийн өр төлбөр, хөтөлбөрийн хөрөнгө, хөтөлбөртэй холбоотой зардлаас тухайн нэгдэгч үйл ажиллагаа тус бүрд хамаарах хувь тэнцүүлсэн хэсгийг тодорхойлох хангалттай мэдээлэлгүй байсан. Иймээс нэгдэгч үйл ажиллагаанууд нь уг хөтөлбөрийг тогтоосон шимтгэлийн хөтөлбөр байдлаар тайлагнадаг байсан. Нийлүүлэлтийн дараа, үр дүнгийн байгууллага нь уг хөтөлбөрийн цорын ганц оролцогч болох бөгөөд өөрийн тогтоосон тэтгэмжийн өр төлбөр, хөтөлбөрийн хөрөнгө, хөтөлбөртэй холбоотой зардлыг тодорхойлох боломжтой болсон. Иймээс нийлүүлэх өдрөөс эхлэн уг хөтөлбөрийг тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр гэж тайлагнана. Үр дүнгийн байгууллагын санхүүгийн байдлын эхлэлийн тайланд УСНББОУС 39-ийн дагуу хэмжсэн хөрөнгө, өр төлбөрийг тусгах хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн.

*Нийлүүлэлтийн үр дүнд үүссэн цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих*

- ДҮ70. Нийлүүлэлтийн улмаас үлдэх дүн үүсэж болно гэдгийг УСНББОУС3 нь СТ 60-ыг боловсруулж байх үедээ тэмдэглэсэн. Энэхүү дүнг хэрхэн хүлээн зөвшөөрч, хэмжихийг УСНББОУС3 авч үзсэн. Уг үлдэх дүн нь үр дүнгийн байгууллагын санхүүгийн үр дүнг тусган илэрхийлэхгүй гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн бөгөөд тэрхүү үлдэх дүнг тухайн үр дүнгийн байгууллагын санхүүгийн байдлын эхлэлийн тайланд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж дүгнэсэн.
- ДҮ71. УСНББОУС3 нь уг үлдэх дүнгийн шинж төрлийг авч үзсэн. Ерөнхий хяналтан доор хийгдээгүй нийлүүлэлтийн хувьд энэхүү үлдэх дүн нь тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын шилжүүлсэн цэвэр хөрөнгө/өмчид тусгагдаагүй, санхүүгийн өмнөх гүйцэтгэлийг илэрхийлнэ гэж УСНББОУС3 үзсэн. Нийлүүлэлтийг ерөнхий хяналтан доор хийгээгүй тохиолдолд уг үлдэх дүнг тэрхүү үр дүнгийн байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдэлд тусгах хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 зөвшөөрсөн.
- ДҮ72. Ерөнхий хяналтан доор хийгдсэн нийлүүлэлтийн хувьд уг үлдэх дүн нь тухайн нийлүүлэлтийн нөхцлийг тогтоох буюу хүлээн зөвшөөрөх үедээ тэрхүү хяналт тавигч байгууллагын гаргасан шийдвэрийн санхүүгийн үр дагаврыг илэрхийлнэ гэж УСНББОУС3 үзсэн. Иймээс нийлүүлэлтийг ерөнхий хяналтан доор хийсэн тохиолдолд уг үлдэх дүнг өмчлөлийн хувь оролцоо эсвэл өмчлөлийн хуваарилалт байдлаар авч үзэх хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 зөвшөөрсөн.
- ДҮ73. Уг үлдэх дүнд тусган оруулвал зохих зүйлсийг УСНББОУС3 авч үзсэн. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан нягтлан бодох бүртгэлийн арга нь тухайн нийлүүлэлт хийгдсэн өдрөөр мөн чанарын хувьд шинэ байгууллага үүсэн бий болоход хүргэдэг байдлаар нийлүүлэлтийг ихэвчлэн хүлээн зөвшөөрдөг болохыг УСНББОУС3 тэмдэглэсэн. Шинэ байгууллага нь хуримтлагдсан ашиг алдагдал, дахин үнэлгээний нэмэгдэл гэх мэт цэвэр хөрөнгө/өмчийн бусад бүрэлдэхүүн хэсгийг бий

болгодоггүй тул цэвэр хөрөнгө/өмчийн хүрээн дэх бүх зүйлсийг уг үлдэх дүнгийн нэг хэсэг байдлаар тусган оруулна.

ДҮ74. Энэхүү арга хандлага нь нийлүүлэлтийн онолын үндэслэлийг хамгийн сайн тусгадаг гэж УСНББОУСЗ дүгнэсэн бөгөөд уг нийлүүлэх өдрөөр цэвэр хөрөнгө/өмчийн хүрээнд хамаарах бүх зүйлсийг тэрхүү үлдэх дүнгийн нэг хэсэг байдлаар авч үзэх хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Ийм байр суурийг илэрхийлэхдээ УСНББОУСЗ нь зарим байгууллагын хувьд энэхүү арга хандлага сөрөг үр дагавартай байж болох юм гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Жишээлбэл; үлдэх дүн нь өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний аливаа нэмэгдлийг агуулах учраас ирээдүйн дахин үнэлгээний аливаа бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх илүү их магадлалтай юм. Яагаад гэвэл, өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдэл нь ирээдүйн дахин үнэлгээний бууралтыг шингээн тусгах боломжгүй болсон байна.

ДҮ75. Ерөнхий хяналтан доор хийгдсэн нийлүүлэлттэй холбоотой өөр нэг сөрөг үр дагавар байдаг. Үр дүнгийн байгууллага нь уг үлдэх дүнг хүлээн зөвшөөрөх боловч хяналт тавигч байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчийн өмнөх бүрэлдэхүүн хэсгүүдийг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрсөн хэвээр байх бөгөөд ингэснээр үүнд нэгтгэлийн тохируулгыг байнга хийх шаардлагатай болно. Эдгээр үр дагаварууд нь уг онолын арга хандлагыг мөрдсөний үр өгөөжөөс илүү ач холбогдолтой гэж УСНББОУСЗ үзэхгүй байна.

СТ 60-д өгсөн хариултууд

ДҮ76. СТ 60-д хариулт ирүүлсэн хүмүүсийн олонхи нь үлдэх дүнгийн талаархи УСНББОУСЗ-ийн арга хандлагыг дэмжсэн боловч мэдэгдэхүйц цөөн хэсэг нь дэмжээгүй. Үлдэх дүнгийн уг санал болгосон аргыг хариулт өгсөн хүмүүс дэмжихгүй байгаа гол учир шалтгаан нь дараах байдалтай байна:

- (а) Тухайн нэгдлийг илүү сайн төлөөлөн илэрхийлэх одоогийн нөөцийг хэвээр хадгалах нь илүү тодорхой ойлгомжтой бөгөөд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг илүү сайн хангадаг;
- (б) Уг санал нь данснаас хасаж буй дахин үнэлгээний нөөцийн талаархи найдвартай мэдээллийг бий болгоно;
- (в) Ерөнхий хяналтан доор хийгдэж буй нийлүүлэлтийн хувьд нэгдэгч байгууллагууд нь шинэ байгууллагаас ялгаатай боловч хоёр буюу хэд хэдэн тусдаа байгууллага байдлаар бус, харин нэг байгууллага байдлаар үйл ажиллагаагаа үр дүнтэйгээр үргэлжлүүлэн явуулж болох юм;
- (г) Дахин үнэлгээний дараагийн тайлант үеийн гарзыг зардал гэж тайлагнах нь ирээдүйн жилүүдэд санхүүгийн үр дүнг буруу илэрхийлэх эрсдэл үүсгэдэг;
- (д) Нийлүүлэлтийг ерөнхий хяналтан доор хийсэн бөгөөд нийлүүлэлтийн тохируулгыг бэлтгэх хэрэгцээ шаардлага нь нэг



## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

үлдэх дүнг хүлээн зөвшөөрсний үр өгөөжөөс илүү байх тохиолдолд уг саналын дагуу нэгтгэлийн тохируулгыг байнга хийх болно; ба

- (е) Уг санал нь өргөн хүрээтэй янз бүрийн нөөцүүдэд, үүн дотроо ажилтны тэтгэмжтэй холбоотой нөөцүүд, хейж, хууль тогтоомжийн дагуу хязгаарлагдсан нөөц санд нөлөө үзүүлэх бөгөөд энэ нь одоогийн ангилал ба сонголтыг хэвээр хадгалах талаархи СТ 60-ын шаардлагатай нийцэхгүй болоход хүргэнэ.
- ДҮ77. Хариулт өгсөн хүмүүсийн илэрхийлсэн зарим учир шалтгаан нь УСНББОУСЗ-д нөлөө үзүүлсэн. Ялангуяа СТ 60-д тусгасан саналууд нь дотооддоо зөрчилтэй байж болох юм гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.
- ДҮ78. Иймээс УСНББОУСЗ нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн бүх дүнг уг үлдэх дүнд хүлээн зөвшөөрөхөөр шаардахын тулд тухайн саналыг дахин авч үзсэн.
- ДҮ79. Цэвэр хөрөнгө/өмчийн хамгийн тохиромжтой толилуулга нь тухайн нийлүүлэлтийн нөхцөл байдлаас хамаарна гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Ерөнхий хяналтан доор хийгдээгүй нийлүүлэлтийн хувьд дээрх ДҮ76(е) параграфт дурдсантай адил нөөц сангууд байхгүй тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдлийг нэг дүнгээр харуулах нь үнэн зөв илэрхийлэх мэдээллээр хангаж болох юм. Ерөнхий хяналтан доор хийгдсэн бөгөөд дээрх ДҮ76(е) параграфт дурдсантай адил нөөц сангууд бүхий нийлүүлэлтийн хувьд цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдлийг нэг дүнгээр харуулах нь үнэн зөв илэрхийлэх мэдээллээр хангах магадлал багатай юм. Ийм нөхцөлд цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсгүүдийг толилуулах нь илүү хамааралтай бөгөөд ач холбогдолтой мэдээллээр хангана.
- ДҮ80. Тайлан бэлтгэгч нар нь хамгийн тохиромжтой арга хандлагыг шүүн тунгаах хамгийн сайн байр суурьтай байдаг тул УСНББОУСЗ нь цэвэр хөрөнгө/өмчийн аль бүрэлдэхүүн хэсгийг толилуулах хэрэгтэй эсэхийг тусгайлан заахгүй байхаар шийдвэрлэсэн. Иймээс УСНББОУСЗ нь уг шаардлагуудыг зохих ёсоор засварлан өөрчлөхийг зөвшөөрсөн.

### *Хэмжилтийн хугацаа*

- ДҮ81. Нэгтгэгч нь худалдан авалтын тайлагналыг уг худалдан авалтын өдрөөс хойш нэг жилийн дотор хийж дуусгахыг СТОУС 3-аар зөвшөөрсөн байдаг. Энэ нь уг худалдан авсан үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлох мэдээлэл олж авах хангалттай хугацааг тухайн нэгтгэгчид олгох явдал юм.
- ДҮ82. Нийлүүлэлтийг тайлагнах үед ийм хугацаа олгох шаардлагатай эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Хувь оролцоогоо нэгтгэх сайжруулсан арга нь хөрөнгө, өр төлбөрийг уг нийлүүлэх өдөр бодит үнэ цэнээр дахин илэрхийлэхийг шаарддаггүй. Гэвч нэгдэгч үйл ажиллагаанууд нь нягтлан бодох бүртгэлийн өөр бодлоготой байж болох бөгөөд тухайн үр дүнгийн

байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд зарим хөрөнгө, өр төлбөрийг дахин илэрхийлэх шаардлагатай болгож болох юм гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Жишээлбэл; үр дүнгийн байгууллага нь үндсэн хөрөнгө гэх мэт зарим хөрөнгийг дахин үнэлэх нягтлан бодох бүртгэлийн бодлого мөрддөг байж болно. Хэрэв нэг буюу хэд хэдэн нэгдэгч үйл ажиллагаанууд нь ийм хөрөнгийг өртгөөр хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өмнө нь мөрдөж байсан бол тэдгээр хөрөнгийн дансны үнийг дахин үнэлгээний загварын дагуу тодорхойлох практик үр нөлөө нь тухайн хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг тодорхойлохтой адил байна. Энэ шалтгааны улмаас үр дүнгийн байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэх үүднээс хөрөнгө, өр төлбөрийг дахин илэрхийлэхэд шаардлагатай мэдээллийг олж авах хугацааг түүнд олгохыг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. УСНББОУСЗ нь үүнд нэг жилийн хугацаа олгоход тохиромжтой гэж үзсэн.

*Аккруэл суурьт УСНББОУС-ыг өмнө нь мөрддөггүй байсан нэгдэгч үйл ажиллагаанууд*

ДҮ83. Нэг буюу хэд хэдэн нэгдэгч үйл ажиллагаанууд нь аккруэл суурьт УСНББОУС-ыг өмнө нь дагаж мөрддөггүй байсан тохиолдолд тийм нөхцөл байдлыг харгалзан тусгахын тулд тусгай заалт оруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь энэ Стандартыг боловсруулж байх үедээ авч үзсэн. Жишээлбэл; аккруэл суурьт УСНББОУС-ыг өмнө нь мөрдөж байсан улсын секторын нэгэн байгууллагыг нягтлан бодох бүртгэлийн өөр аккруэл суурийг өмнө нь мөрддөг байсан улсын секторын хоёр дахь байгууллагатай нийлүүлж болох юм. Энэ тохиолдолд улсын секторын хоёр дахь байгууллагын хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн дансны үнээр хүлээн зөвшөөрч, хэмжих нь аккруэл суурьт УСНББОУС-ын шаардлагуудтай нийцэхгүй байж болох юм.

ДҮ84. УСНББОУСЗ нь энэ Стандартад тусдаа заалт оруулах шаардлагагүй гэж дүгнэсэн. Үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэх шаардлагатай тохиолдолд тэдгээр нэгдэгч үйл ажиллагаануудын тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг уг үр дүнгийн байгууллага нь тохируулахыг УСНББОУС 40-ийн 27-р параграфтаар шаардсан байдаг. Нэг буюу хэд хэдэн нэгдэгч үйл ажиллагаанууд нь аккруэл суурьт УСНББОУС-ыг өмнө нь мөрддөггүй байсан ихэнх нөхцөл байдлыг зохицуулахад энэхүү шаардлага хангалттай гэж УСНББОУСЗ үзсэн.

ДҮ85. Үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд дансны үнүүдийг тохируулах нь аккруэл суурьт УСНББОУС-тай нийцүүлэхэд хангалтгүй байх тохиолдолд тэрхүү үр дүнгийн байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдөж буй байгууллага болно гэж УСНББОУСЗ үзсэн. Нэгдэгч нэг буюу хэд хэдэн үйл ажиллагаанууд өмнө нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг баримталж байсан бөгөөд иймээс зарим хөрөнгө, өр төлбөрийг өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй байсан бол ийм тохиолдол үүсдэг. Ийм

нөхцөлд уг үр дүнгийн байгууллага нь нэгдлийн дараах анхны санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийг дагаж мөрдөнө.

**Худалдан авалтын тайлагнал (58-125-р параграф)**

*Худалдан авалтын тайлагналд худалдан авалтын аргыг хэрэглэх шалтгаан*

- ДҮ86. ЗББ-ийг боловсруулах үедээ УСНББОУС3 нь “хэмжилтийн суурь болгон бодит үнэ цэнийг ашиглах нь улсын секторын зарим эсвэл бүх худалдан авалтанд тохиромжтой эсэх талаар дүгнэлт гаргаагүй. Яагаад гэвэл, хамгийн түгээмэл хэлбэрийн худалдан авалт нь өмч эзэмшигчдэд өгөөж авчрах эдийн засгийн үр өгөөжийг бүрдүүлэхээс илүүтэйгээр бараа, үйлчилгээг нийлүүлэхтэй холбоотой зорилтуудад хүрэхийн тулд үйл ажиллагаануудыг олж эзэмших үед хийгддэг. Түүнчлэн, олон худалдан авалт нь төлбөрийн шилжүүлэлтийг агуулаагүй байдаг. Төлбөрийн шилжүүлэлтийн хариуд үйл ажиллагааг шууд худалдан авах ойлголт ухагдахуун алдагдаж байгаа учраас энэ төрлийн худалдан авалт нь СТОУС 3-д заасан, бизнесийн нэгдлээс мөн чанарын хувьд өөр гэж зарим хүмүүс үздэг”. ЗББ-т хариулт ирүүлсэн хүмүүс нь төлбөр шилжүүлж хийсэн худалдан авалтын хувьд бодит үнэ цэнэ ашиглахыг ерөнхийдөө дэмжсэн. Төлбөр шилжүүлэхгүй хийсэн худалдан авалтын хувьд бодит үнэ цэнийн хэмжилт болон дансны үнийн хэмжилтэнд адил тэнцүү санал өгсөн.
- ДҮ87. ЗББ-т илэрхийлсэн шалтгаан тайлбар нь уг ЗББ дэх ангиллын арга хандлагыг тусгасан. Хяналт олж авах нь нийлүүлэлтийг худалдан авалтаас ялгах цорын ганц шийдвэрлэх шалгуур гэдгийг УСНББОУС3 нь ЗББ-т санал болгосон. Үүний дараа УСНББОУС3 нь хяналт олж авалтыг төлбөр ба шийдвэр гаргалт гэсэн хоёр хүчин зүйлсээр нэмж гүйцээхээр шийдвэрлэсэн. Ингэснээр ЗББ-т тусгасан арга хандлагын дагуу улсын секторын маш цөөхөн нэгдлийг худалдан авалт гэж ангилахад хүргэнэ гэж УСНББОУС3 үзсэн. Ингэж худалдан авалт гэж ангилсан улсын секторын нэгдлүүд нь СТОУС 3-д заасан бизнесийн нэгдэлтэй мөн чанарын хувьд илүү төсөөтэй болно.
- ДҮ88. Мөрдөхийг зөвшөөрсөн уг хянан засварласан ангиллын арга хандлагатай холбоотойгоор УСНББОУС3 нь худалдан авалтын хувьд тохиромжтой байх нягтлан бодох бүртгэлийн аргыг дахин харгалзан үзсэн. Уг худалдан авалтын аргыг тохиромжтой гэж УСНББОУС3 дүгнэсэн бөгөөд СТОУС 3-д заасан худалдан авалтын аргыг энэ Стандарт дахь худалдан авалтын хувьд тайлагналын арга болгон мөрдөхийг зөвшөөрсөн. СТ 60-д хариулт ирүүлсэн хүмүүс нь энэхүү арга хандлагыг дэмжсэн.

*СТОУС 3 дахь тайлагналын аргаас ялгаатай байдал*

- ДҮ89. СТОУС 3 нь тухайлбал, орлогын албан татвар, хувьцаанд суурилсан төлбөр гэх мэт УСНББОУС-ын адилтгах Стандарт байхгүй, тийм СТОУС-

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

ын бусад Стандартуудад үндэслэсэн тайлагналын аргыг агуулсан байдаг. УСНББОУСЗ нь СТОУС 3-д тусгайлан заасан дэлгэрэнгүй шаардлагуудыг оруулахгүй боловч тухайн асуудлыг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын талаархи лавлагаа оруулахыг зөвшөөрсөн.

ДҮ90. СТОУС 3-д заасан аливаа нэмэлт заавар удирдамж шаардлагатай эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. СТОУС 3-д авч үзээгүй арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрийг улсын секторын худалдан авалтанд тусгасан байж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь арилжааны бус дараах зүйлсийн талаархи нэмэлт заавар удирдамжийг тусган оруулахыг зөвшөөрсөн:

- (а) Татварын чөлөөлөлт; ба
- (б) Худалдан авалтын үр дүнд өөрчлөгдөж болох шалгуурт үндэслэн уг нэгтгэгч үйл ажиллагааны хүлээн авсан шилжүүлэг, хөнгөлттэй зээл ба адилтгах өгөөжийн дараагийн тайлант үеийн хэмжилт.

ДҮ91. СТ 60-д хариулт өгсөн хүмүүсээс худалдан авалтын аргын талаар ирүүлсэн санал хүсэлтүүдийг УСНББОУСЗ авч үзсэн. Үүний үр дүнд УСНББОУСЗ нь уг шаардлагад жижиг өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн:

Татварын чөлөөлөлтийг тухайн худалдан авалтын дараагийн тайлант үед олгодог, түүнчлэн энэ нь худалдан авалтын нөхцлийн нэг хэсгийг бүрдүүлдэг тийм нөхцлүүдийг хамруулахын тулд татварын чөлөөлөлтийн талаархи шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулсан.

Хүлээн зөвшөөрөлтийн болон хэмжилтийн зарчмуудтай холбоотой аливаа нэмэлт нөхцлүүд эсвэл худалдан авалтын аргын талаархи аливаа нэмэлт заавар удирдамж шаардлагатай эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Энэ Стандарт болон бусад УСНББОУС-ууд дахь заалтууд угаасаа хангалттай ойлгомжтой байгаа гэж УСНББОУСЗ үзсэн учраас цаашид нэмэлт заалт шаардлагагүй гэж дүгнэсэн.

*Аккруэл суурьт УСНББОУС-ыг өмнө нь мөрддөггүй байсан, худалдан авсан үйл ажиллагаанууд*

ДҮ92. Худалдан авсан нэг буюу хэд хэдэн үйл ажиллагаанууд нь аккруэл суурьт УСНББОУС-ыг өмнө нь дагаж мөрддөггүй байсан тохиолдолд тийм нөхцөл байдлыг харгалзан тусгахын тулд тусгай заалт оруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь энэ Стандартыг боловсруулж байх үедээ авч үзсэн. УСНББОУСЗ нь энэ Стандартад тусдаа заалтууд оруулах шаардлагагүй гэж дүгнэсэн. Нэгтгэгч нь олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө, хариуцсан өр төлбөр болон уг худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцоог хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 40-ийн 64-р параграфаар шаарддаг. Нэгтгэгч нь тухайн олж эзэмшсэн хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн худалдан авалтын өдрийн бодит үнэ цэнээр хэмжихийг энэхүү Стандартын 72-р параграфаар шаарддаг. Иймээс нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааны өмнө

мөрдөж байсан нягтлан бодох бүртгэлийн сууриас үл хамааран бүх хөрөнгө, өр төлбөрийг аккрузэл суурьт УСНББОУС-ын дагуу хэмжинэ.

*Бодит үнэ цэнийг тодорхойлох боломжгүй байх*

ДҮ93. СТ 60-д хариулт өгсөн хүмүүс нь хэвийн бус гажих тохиолдолд тухайн зүйлийн бодит үнэ цэнийг нэгтгэгч нь тодорхойлох практик боломжгүй байж болно гэж үзсэн бөгөөд тэрхүү зүйлийн өмнөх дансны үнийг ашиглах нь тохиромжтой хувилбар байж болох юм гэсэн санал илэрхийлсэн. УСНББОУСЗ нь энэ саналыг харгалзан үзсэн боловч дансны үнийг ашиглах нь бүх нөхцөл байдалд, ялангуяа тухайн худалдан авсан үйл ажиллагаа нь аккрузэл суурьт УСНББОУС-ыг мөрддөггүй тохиолдолд тохиромжтой биш байж болох юм гэж дүгнэсэн. Байгууллагууд нь УСНББОУС-ууд дахь одоогийн шаардлагуудыг дагаж мөрдөх хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Ялангуяа, байгууллага нь ул үндэслэлтэй хүчин чармайлт нэг бүрийг гаргасны дараа түүнийг мөрдөх боломжгүй тохиолдолд УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-нд заасанчлан, тухайн шаардлагыг мөрдөх практик боломжгүй байна гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. УСНББОУС 3 нь нэмэлт заавар удирдамжаар хангадаг. Ийм тохиолдолд нэгтгэгч нь тухайн зүйлийг уг худалдан авалтын өдрөөр бусад УСНББОУС-ууд болон өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцсэн тийм арга маягаар хэмжих бөгөөд бусад УСНББОУС-аар шаардсан тодруулгыг хийнэ. Өмнөх дансны үнэ нь бусад УСНББОУС-ууд болон нэгтгэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцсэн байх зөвхөн тийм тохиолдолд тухайн зүйлийг түүний өмнөх дансны үнээр хэмжихэд тохиромжтой гэж УСНББОУСЗ үзсэн.


## Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 40-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

ХЗУ1. Энэхүү Хэрэгжүүлэх Заавар Удирдамжийн зорилго нь УСНББОУС 40-ийн шаардлагуудын зарим төлөв байдлыг үлгэрчлэн харуулах явдал юм.

### Улсын секторын нэгдлийн ангилал

ХЗУ2. Улсын секторын нэгдлийг ангилахад зориулан УСНББОУС 40-өөр тогтоосон процессыг доорх схемд хураангуйлан харуулав.



## Үлгэрчилсэн жишээ

Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 40-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

### Улсын секторын нэгдлийн ангилал

УСНББОУС 40-ийн 7-14 ба МЗУ10-МЗУ50-р параграфуудыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах

- ҮЖ1. Дараах жишээнүүд нь улсын секторын нэгдлийг ангилах процессыг үлгэрчлэн харуулна. Эдгээр жишээ нь таамагласан нөхцөл байдлыг илэрхийлсэн. Хэдийгээр эдгээр жишээний зарим төлөв байдлууд нь бодит нөхцөл байдалд илрэн гарч болох боловч УСНББОУС 40-ийг мөрдөх үедээ тухайн тодорхой хэв загварын холбогдох бүх баримт материал болон нөхцөл байдлуудыг үнэлэх шаардлагатай байдаг.
- ҮЖ2. Жишээ нэг бүрийг схемээр харуулсан. Улсын секторын нэгдэл нь бүхэлдээ эдийн засгийн нэгдмэл байгууллагыг бүрдүүлэхгүй боловч түүний нэг хэсэг болох үйл ажиллагаануудыг агуулсан тохиолдолд уг нэгдэлд хамаарах үйл ажиллагаанууд болон нэгдлээр үүссэн байгууллагыг тухайн схемд сүүдэрлүүлэн харуулсан. Эдийн засгийн нэгдмэл байгууллагад нэгээс олон тайлагнагч байгууллага хамаарах тохиолдолд тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хил хязгаарыг тасархай шугамаар харуулсан.

*Жишээ 1: Нутаг дэвсгэрийн хил хязгаарыг дахин тогтоох замаар орон нутгийн засаг захиргааг дахин зохион байгуулах*

- ҮЖ3. Одоо оршин байгаа хоёр орон нутгийн захиргааны зарим үйл ажиллагааг нэгтгэснээр шинэ орон нутгийн захиргаа үүсгэхийг дараах схемд үлгэрчлэн харуулав.



- ҮЖ4. Энэ жишээнд уг одоо оршин байгаа, А ба Б гэсэн хоёр орон нутгийн захиргааны нутаг дэвсгэрийн хил хязгаарыг хууль тогтоомжийн дагуу Парламент шинэчлэн тогтоосон. Парламент болон Төв засгийн газрын аль нь ч А ба Б нутгийн захиргаанд хяналт тавьдаггүй. Нутгийн захиргаа тус бүрийн хуучин нутаг дэвсгэрийн хэсэгт хамаарах эрх, үүргийг В гэсэн шинэ орон нутгийн захиргаанд шилжүүлсэн. В нутгийн захиргааны нэг


## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

хэсэг болгохын тулд уг шилжүүлсэн нутаг дэвсгэртэй холбоотой үйл ажиллагаануудыг нэгтгэсэн. Улсын секторын нэгдэл үүссэн.

- ҮЖ5. А ба Б нутгийн захиргаа нь өөр бусад байдлаар өөрчлөгдөөгүй бөгөөд өөрсдийн удирдах байгууллагуудыг хэвээр хадгалсан. Бусад орон нутгийн захиргаануудаас шилжүүлэн авсан үйл ажиллагаануудыг удирдан зохион байгуулахын тулд В нутгийн захиргааны хувьд удирдах байгууллагыг (А ба Б нутгийн захиргааны удирдах байгууллагуудтай холбоогүй) шинээр сонгосон.
- ҮЖ6. В нутгийн захиргааны үүсгэн байгуулалт нь улсын секторын нэгдэл болно. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрхүү нэгдлийн оролцогч талуудын аль нэг нь үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ7. В нутгийн захиргаа нь А ба Б нутгийн захиргааны удирдах байгууллагатай холбоогүй, шинээр томилогдсон удирдах байгууллагатай. А ба Б нутгийн захиргааны аль нь ч В нутгийн захиргааны хувьд бүрэн эрхгүй. Мөн эдгээр талууд нь В нутгийн захиргаан дахь аливаа оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээхгүй буюу өгөөжийг хүртэх эрхгүй юм.
- ҮЖ8. А ба Б нутгийн захиргааны аль нь ч энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд В нутгийн захиргааны хувьд хяналтыг олж аваагүй байна. Иймээс уг нэгдлийг нийлүүлэлт гэж ангилна.

*Жишээ 2: Нутгийн захиргаадыг нэг шинэ хуулийн этгээдэд нэгтгэх замаар орон нутгийн засаг захиргааг дахин зохион байгуулах*

- ҮЖ9. Одоо оршин байгаа хоёр орон нутгийн захиргааны бүх үйл ажиллагааг нэг шинэ хуулийн этгээдэд нэгтгэснээр шинэ орон нутгийн захиргаа үүсгэхийг дараах схемд үлгэрчлэн харуулав.



- ҮЖ10. Энэ жишээнд Г нутгийн захиргаа ба Д хотын үйл ажиллагаануудыг (болон холбогдох хөрөнгө, өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг) нэгтгэхийн тулд Е нутгийн захиргааг үүсгэн байгуулах замаар улсын секторын нэгдэл хийсэн. Энэхүү нэгдлээс өмнө Г нутгийн захиргаа ба Д хот нь ерөнхий хяналтанд байдаггүй байсан. Уг нэгдлийг хууль тогтоомжийн дагуу мужийн засаг захиргаа (гуравдагч этгээд) тулган хэрэгжүүлсэн. Хэдийгээр мужийн засаг захиргаа нь эдгээр хоёр нутгийн



## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

захиргааг хянадаггүй боловч хууль тогтоомжийн дагуу тэдгээрийг нэгтгэх хууль ёсны бүрэн эрхтэй байдаг.

- ҮЖ11. Е нутгийн захиргааг үүсгэн байгуулсан хууль тогтоомжид Г нутгийн захиргаа буюу Д хоттой холбоогүй, шинэ удирдах байгууллага үүсгэн байгуулахаар заасан. Г нутгийн захиргаа ба Д хот нь энэхүү нэгдлийн нөхцлийг тодорхойлоход ямар нэгэн үүрэг гүйцэтгэхгүй. Нэгдлийн дараа Г нутгийн захиргаа ба Д хотыг татан буулгасан.
- ҮЖ12. Е нутгийн захиргааны үүсгэн байгуулалт нь улсын секторын нэгдэл болно. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрхүү нэгдлийн оролцогч талуудын аль нэг нь үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ13. Е нутгийн захиргаа нь Г нутгийн захиргаа ба Д хотын захиргааны удирдах байгууллагатай холбоогүй, шинээр байгуулсан удирдах байгууллагатай. Г нутгийн захиргаа ба Д хотын захиргааны аль нь ч Е нутгийн захиргааны хувьд бүрэн эрхгүй. Мөн эдгээр талууд нь Е нутгийн захиргаан дахь аливаа оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээхгүй буюу өгөөжийг хүртэх эрхгүй юм.
- ҮЖ14. Г нутгийн захиргаа ба Д хотын захиргааны аль нь ч энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Е нутгийн захиргааны хувьд хяналтыг олж аваагүй байна. Иймээс уг нэгдлийг нийлүүлэлт гэж ангилна.

### Жишээ 2-ын Хувилбар


- ҮЖ15. Жишээ 2-т дурдсанаар, Е нутгийн захиргааг үүсгэн байгуулсан хууль тогтоомжид Г нутгийн захиргаа буюу Д хоттой холбоогүй, шинэ удирдах байгууллага үүсгэн байгуулахаар заасан. Харин энэ хувилбарт, Е нутгийн захиргааг үүсгэн байгуулсан хууль тогтоомжид Г нутгийн захиргааны удирдах байгууллага нь Е нутгийн захиргааны удирдах байгууллага болгохоор заасан гэж үзье.
- ҮЖ16. Энэ нь Е нутгийн захиргааг үүсгэн байгуулсан улсын секторын нэгдлийн хүрээнд Г нутгийн захиргаа нь Д хотын үйл ажиллагааны хяналтыг олж авч байна гэдгийг илэрхийлнэ. Гэвч Г нутгийн захиргаа хяналтыг олж авч буй эсэх үнэлгээ нь түүний хуулийн хэлбэрт биш, харин нэгдлийн мөн чанарт үндэслэнэ. Е нутгийн захиргаа нь өөрийн анхны санхүүгийн тайланг бэлтгэхдээ УСНББОУС 40-ийн 7-8 ба МЗУ10-МЗУ18-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ17. Энэ хувилбарт, Г нутгийн захиргааны удирдах байгууллага нь Е нутгийн захиргааны удирдах байгууллага болохоор заасан хууль тогтоомж нь Г нутгийн захиргаа дараах зүйлсийг олж авахад хүргэдэг гэж үзье:
- (а) Д хотын үйл ажиллагааны хувьд бүрэн эрх;

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (б) Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - (в) Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ18. Энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Г нутгийн захиргаа нь Д хотын хяналтыг олж авсан гэж Е нутгийн захиргаа дүгнэсэн. Е нутгийн захиргаа нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ19. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Е нутгийн захиргаа нь Г нутгийн захиргаа ба Д хотын хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүсэхгүй гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлт ба худалдан авалтын аль алинтай нийцэж байна. Түүнчлэн, Г нутгийн захиргаа нь талуудын хамтын хэлэлцээрээр олж авч болох байсантай ижил эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид хандан нэвтрэх боломжтой болсон гэдгийг Е нутгийн захиргаа мөн тэмдэглэсэн; энэ нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлж болох боловч дүгнэлтийн бус шинжтэй байна.
- ҮЖ20. Д хотын цэвэр хөрөнгийн хувьд бүрэн эрх бүхий тал байхгүй учраас уг улсын секторын нэгдэлд төлбөр төлөлтийг тусган оруулахгүй гэдгийг Е нутгийн захиргаа нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн (өөрөөр хэлбэл, тоолж болох өмчлөлийн хувь оролцоо бүхий Д хотын хуучин эзэд байхгүй). Энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлнэ.
- ҮЖ21. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ Е нутгийн захиргаа нь уг улсын секторын нэгдлийг мужийн засаг захиргаа (гуравдагч этгээд) тулган хэрэгжүүлсэн бөгөөд нэгдлийн нөхцлийг тодорхойлоход Г нутгийн захиргаа ба Д хот ямар нэг үүрэггүй гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлж болох юм.
- ҮЖ22. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Е нутгийн захиргаа нь энэхүү улсын секторын нэгдлийг нийлүүлэлт гэж ангилах хэрэгтэй гэж үзсэн. Энэхүү шийдвэрийг гаргахдаа Е нутгийн захиргаа нь үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд бүрэн эрхтэй тал байхгүй учраас төлбөр төлөхгүй байгаа нь уг нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл болно гэж дүгнэсэн.

*Жишээ 3: Нутгийн захиргаадыг нэг шинэ хуулийн этгээдэд нэгтгэх замаар орон нутгийн засаг захиргааг дахин зохион байгуулах*

ҮЖ23. Одоо байгаа хоёр орон нутгийн захиргааны бүх үйл ажиллагааг одоо оршин байгаа нэг хуулийн этгээдэд нэгтгэхийг дараах схемд үлгэрчлэн харуулав.



ҮЖ24. Энэ жишээнд Ж нутгийн захиргаа ба И нутгийн захиргааны үйл ажиллагаануудыг (ба холбогдох хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг) хуулийн этгээд болох Ж нутгийн захиргаанд нэгтгэснээр улсын секторын нэгдэл үүссэн. Энэхүү нэгдлээс өмнө Ж нутгийн захиргаа ба И нутгийн захиргаа нь ерөнхий хяналтанд байдаггүй байсан. Уг нэгдлийг хууль тогтоомжийн дагуу Төв засгийн газар (гуравдагч этгээд) тулган хэрэгжүүлсэн. Хэдийгээр Төв засгийн газар нь эдгээр хоёр нутгийн захиргааг хянадаггүй боловч хууль тогтоомжийн дагуу тэдгээрийг нэгтгэх хууль ёсны бүрэн эрхтэй байдаг.

ҮЖ25. Тухайн нэгдлийг хэрэгжүүлсэн хууль тогтоомжид Ж нутгийн захиргааны удирдах байгууллага нь уг нэгдсэн байгууллагын удирдах байгууллага байдлаар үргэлжлүүлэн ажиллахаар заасан. Ж ба И нутгийн захиргаад нь энэхүү нэгдлийн нөхцлийг тодорхойлоход ямар нэгэн үүрэг гүйцэтгэхгүй. Уг улсын секторын нэгдлийн дараа И нутгийн захиргааг татан буулгасан.

ҮЖ26. Эдгээр баримт материал нь уг улсын секторын нэгдлийн хүрээнд Ж нутгийн захиргаа нь И нутгийн захиргааны үйл ажиллагааны хяналтыг олж авч байна гэдгийг илэрхийлнэ. Гэвч Ж нутгийн захиргаа хяналтыг олж авч буй эсэх үнэлгээ нь түүний хуулийн хэлбэрт биш, харин нэгдлийн мөн чанарт үндэслэнэ. Ж нутгийн захиргаа нь энэхүү нэгдлийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 7-8 ба МЗУ10-МЗУ18-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.

ҮЖ27. Энэ жишээнд, Ж нутгийн захиргааны удирдах байгууллагыг уг нэгдсэн байгууллагын удирдах байгууллага байдлаар үргэлжлүүлэн ажиллахаар заасан хууль тогтоомж нь Ж нутгийн захиргаа дараах зүйлсийг олж авахад хүргэдэг гэж үзье:

- (а) И нутгийн захиргааны үйл ажиллагааны хувьд бүрэн эрх;

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (б) Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - (в) Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ28. Энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Ж нутгийн захиргаа нь И нутгийн захиргааны хяналтыг хяналтыг олж авсан гэж Ж нутгийн захиргаа дүгнэсэн. Ж нутгийн захиргаа нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ29. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Ж нутгийн захиргаа нь Ж ба И нутгийн захиргааны хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүсэхгүй гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлт ба худалдан авалтын аль алинтай нийцэж байна. Түүнчлэн, Ж нутгийн захиргаа нь талуудын хамтын хэлэлцээрээр олж авч болох байсантай ижил эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид хандан нэвтрэх боломжтой болсон гэдгээ Ж нутгийн захиргаа мөн тэмдэглэсэн; энэ нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлж болох боловч дүгнэлтийн бус шинжтэй байна.
- ҮЖ30. И нутгийн захиргааны цэвэр хөрөнгийн хувьд бүрэн эрх бүхий тал байхгүй учраас уг улсын секторын нэгдэлд төлбөр төлөлтийг тусган оруулахгүй гэдгийг Ж нутгийн захиргаа нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн (өөрөөр хэлбэл, тоолж болох өмчлөлийн хувь оролцоо бүхий И нутгийн захиргааны хуучин эзэд байхгүй). Энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлнэ.
- ҮЖ31. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ Ж нутгийн захиргаа нь уг улсын секторын нэгдлийг Төв засгийн газар (гуравдагч этгээд) тулган хэрэгжүүлсэн бөгөөд нэгдлийн нөхцлийг тодорхойлоход Ж ба И нутгийн захиргаад ямар нэг үүрэггүй гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлж болох юм.
- ҮЖ32. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Ж нутгийн захиргаа нь энэхүү улсын секторын нэгдлийг нийлүүлэлт гэж ангилах хэрэгтэй гэж үзсэн. Энэхүү шийдвэрийг гаргахдаа Ж нутгийн захиргаа нь үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд бүрэн эрхтэй тал байхгүй учраас төлбөр төлөхгүй байгаа нь уг нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл болно гэж дүгнэсэн.
- Жишээ 3-ын Хувилбар
- ҮЖ33. Жишээ 3-т дурдсанаар, Ж нутгийн захиргааны удирдах байгууллага нь уг нэгдсэн байгууллагын удирдах байгууллага болохоор тухайн хууль

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ


тогтоомжид заасан. Харин энэ хувилбарт, Ж буюу И нутгийн захиргаатай холбоогүй, шинэ удирдах байгууллага үүсгэн байгуулахаар уг хууль тогтоомжид заасан гэж үзье.

- ҮЖ34. Энэхүү улсын секторын нэгдлийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрхүү нэгдлийн оролцогч талуудын аль нэг нь үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ35. Хуулийн хэлбэрээ хэвээр үргэлжлүүлж байгаа гэдгээс үл хамааран Ж нутгийн захиргаа нь өөрийн өмнөх удирдах байгууллага эсвэл И нутгийн захиргааны удирдах байгууллагатай холбоогүй, шинээр байгуулагдсан удирдах байгууллагатай болсон. Иймээс өмнөх Ж нутгийн захиргаа нь И нутгийн захиргааны хувьд бүрэн эрх олж аваагүй. Түүнчлэн, И нутгийн захиргаан дахь аливаа оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээхгүй буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрхгүй байна.
- ҮЖ36. Ж нутгийн захиргаа нь энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд И нутгийн захиргааны хувьд хяналт олж аваагүй. Иймээс уг нэгдлийг нийлүүлэлт гэж ангилна.

### *Жишээ 4: Төв засгийн газрын яамдын бүтцийн өөрчлөлт*

- ҮЖ37. Худалдаа, хөгжлийн яам ба Аж үйлдвэрийн яамыг шинээр байгуулсан Худалдаа, Аж үйлдвэрийн яам болгон нэгтгэснээр Төв засгийн газрын яамдуудад хийх дахин зохион байгуулалтыг дараах схемд үлгэрчлэн харуулсан.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ



- ҮЖ38. Энэ жишээнд Худалдаа, хөгжлийн яам ба Аж үйлдвэрийн яамны үйл ажиллагаануудыг (ба холбогдох хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг) нэгтгэж, Худалдаа, Аж үйлдвэрийн яамыг байгуулснаар улсын секторын нэгдэл үүссэн. Нэгдлээс өмнө ба дараа бүх яамдыг Төв засгийн газар хянаж байна. Ийм хяналтаа ашигласнаар Төв засгийн газар нь нэгдлийг тулган хэрэгжүүлсэн. Худалдаа, хөгжлийн яам ба Аж үйлдвэрийн яам нь уг нэгдлийн нөхцлийг тодорхойлоход ямар ч үүрэггүй байна.
- ҮЖ39. Нэгдлийг хэрэгжүүлэхдээ, Төв засгийн газар нь уг шинэ Худалдаа, Аж үйлдвэрийн яамны эрх, үүргийг Аж үйлдвэрийн сайд болон Аж үйлдвэрийн яамны удирдах байгууллагад хариуцуулан өгсөн. Уг нэгдлийн дараа Худалдаа, хөгжлийн яам ба Аж үйлдвэрийн яамыг татан буулгасан.
- ҮЖ40. Төв засгийн газар нь улсын секторын нэгдлийн өмнө ба дараа тэдгээр үйл ажиллагаануудыг хянаж байгаа учраас уг нэгдлийг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа тайлагнахгүй. Энэхүү нэгдлийг Худалдаа, Аж үйлдвэрийн яам тайлагнана.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- ҮЖ41. Худалдаа, Аж үйлдвэрийн яамыг үүсгэн байгуулалт нь улсын секторын нэгдэл болно. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрхүү нэгдлийн оролцогч талуудын аль нэг нь үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ42. Төв засгийн газар нь нь уг шинэ Худалдаа, Аж үйлдвэрийн яамны эрх, үүргийг Аж үйлдвэрийн сайд болон Аж үйлдвэрийн яамны удирдах байгууллагад хариуцуулан өгсөн. Энэ нь шинэ Худалдаа, Аж үйлдвэрийн яамыг үүсгэн байгуулсан улсын секторын нэгдлийн хүрээнд Аж үйлдвэрийн яам нь Худалдаа, хөгжлийн яамны үйл ажиллагааны хяналтыг олж авч байна гэдгийг илэрхийлнэ. Гэвч Аж үйлдвэрийн яам хяналтыг олж авч буй эсэх үнэлгээ нь түүний хэлбэрт биш, харин нэгдлийн мөн чанарт үндэслэнэ. Уг нэгдлийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Худалдаа, Аж үйлдвэрийн яам нь УСНББОУС 40-ийн 7-8 ба МЗУ10-МЗУ18-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ43. Энэ жишээнд, уг шинэ Худалдаа, Аж үйлдвэрийн яамны эрх, үүргийг Аж үйлдвэрийн сайд болон Аж үйлдвэрийн яамны удирдах байгууллагад хариуцуулан өгсөн Төв засгийн газрын шийдвэр нь Аж үйлдвэрийн яам дараах зүйлсийг олж авахад хүргэдэг гэж үзье:
- (а) Худалдаа, хөгжлийн яамны үйл ажиллагааны хувьд бүрэн эрх;
  - (б) Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - (в) Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ44. Энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Аж үйлдвэрийн яам нь Худалдаа, хөгжлийн яамны хяналтыг олж авсан гэж Худалдаа, Аж үйлдвэрийн яам дүгнэсэн. Худалдаа, Аж үйлдвэрийн яам нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ45. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Худалдаа, Аж үйлдвэрийн яам нь Худалдаа, хөгжлийн яам ба Аж үйлдвэрийн яамны хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүсэхгүй гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлт ба худалдан авалтын аль алинтай нийцэж байна. Түүнчлэн, Аж үйлдвэрийн яам нь талуудын хамтын хэлэлцээрээр олж авч болох байсантай ижил эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид хандан нэвтрэх боломжтой болсон гэдгийг Худалдаа, хөгжлийн яам мөн тэмдэглэсэн; энэ нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлж болох юм.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- ҮЖ46. Энэхүү нэгдэл нь ерөнхий хяналтан доор хийгдсэн бөгөөд хяналт тавигч байгууллага болох Төв засгийн газар нь нэгдлийн нөхцөлд ямар нэг төлбөрийг тусгайлан заагаагүй учраас уг улсын секторын нэгдэлд төлбөр төлөлтийг тусган оруулахгүй гэдгийг Худалдаа, Аж үйлдвэрийн яам нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Иймээс төлбөр төлөхгүй байх нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлж болох боловч энэ нь дангаараа дүгнэлтийн шинжтэй болохгүй бөгөөд бусад хүчин зүйлсийг мөн харгалзан үзэх шаардлагатай байдаг.
- ҮЖ47. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Худалдаа, Аж үйлдвэрийн яам нь уг улсын секторын нэгдлийг ерөнхий хяналтан доор хийсэн гэдгийг онцлон тэмдэглэсэн. Энэхүү нэгдлийг Төв засгийн газар (гуравдагч этгээд) тулган хэрэгжүүлсэн бөгөөд Худалдаа, хөгжлийн яам болон Аж үйлдвэрийн яам нь уг нэгдлийн нөхцлийг тодорхойлоход ямар ч үүрэггүй байсан. Энэ нь уг нэгдлийг хийх эсэх эцсийн шийдвэр болон нэгдлийн нөхцлийг тухайн хяналт тавигч байгууллага болох Төв засгийн газар тодорхойлдог гэсэн нотолгоо болно. Мөн энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор хангана.
- ҮЖ48. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Худалдаа, Аж үйлдвэрийн яам нь энэхүү улсын секторын нэгдлийг нийлүүлэлт гэж ангилах хэрэгтэй гэж үзсэн. Энэхүү шийдвэрийг гаргах үедээ, уг улсын секторын нэгдлийг ерөнхий хяналтан доор хийсэн нь тухайн нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл болно гэж үзсэн.

### Жишээ 4-ийн Хувилбар

- ҮЖ49. Жишээ 4-т дурдсанаар, Төв засгийн газар нь уг шинэ Худалдаа, Аж үйлдвэрийн яамны эрх, үүргийг Аж үйлдвэрийн сайд болон Аж үйлдвэрийн яамны удирдах байгууллагад хариуцуулан өгсөн. Харин энэ хувилбарт Төв засгийн газар нь шинэ сайд болон шинэ удирдах байгууллагыг томилно гэж үзье.
- ҮЖ50. Худалдаа, Аж үйлдвэрийн яамны үүсгэн байгуулалт нь ерөнхий хяналтанд буй улсын секторын нэгдэл болно. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрхүү нэгдлийн оролцогч талуудын аль нэг нь үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ51. Худалдаа, Аж үйлдвэрийн яам нь шинэ сайдтай бөгөөд Худалдаа, хөгжлийн яам ба Аж үйлдвэрийн яамны удирдах байгууллагатай холбоогүй, шинээр томилогдсон удирдах байгууллагатай. Худалдаа, хөгжлийн яам ба Аж үйлдвэрийн яамны аль нь ч бусад яамны үйл ажиллагааны хувьд бүрэн эрхгүй. Мөн эдгээр талууд нь бусад яамны үйл ажиллагаан дахь аливаа оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээхгүй буюу өгөөжийг хүртэх эрхгүй юм.




## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

ҮЖ52. Худалдаа, хөгжлийн яам ба Аж үйлдвэрийн яамны аль нь ч энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Худалдаа, Аж үйлдвэрийн яамны хяналтыг олж аваагүй. Иймээс уг нэгдлийг нийлүүлэлт гэж ангилна.

*Жишээ 5: Ерөнхий хяналтанд буй үйл ажиллагаануудын шилжүүлэлт*

ҮЖ53. Ерөнхий хяналтанд буй улсын секторын хоёр байгууллагын хоорондох үйл ажиллагааны шилжүүлэлтийг дараах схемд үлгэрчлэн харуулсан.



ҮЖ54. Энэ жишээнд Бага сургуулийн хоол тэжээлийн үйл ажиллагааг Мужийн засаг захиргааны Эрүүл мэндийн хэлтсээс түүний Боловсролын хэлтэст шилжүүлэх улсын секторын нэгдэл хийгдэж байна. Уг хоёр хэлтсийн аль алиныг нэгдлийн өмнө ба дараа Мужийн засаг захиргаа хянаж байна.

ҮЖ55. Мужийн засаг захиргаа нь тухайн үйл ажиллагааг нэгдлийн өмнө ба дараа хянаж байгаа учраас тус Мужийн засаг захиргаа нь өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгдлийг тайлагнахгүй. Харин уг нэгдлийг Боловсролын хэлтэс тайлагнана.

ҮЖ56. Бага сургуулийн хоол тэжээлийн үйл ажиллагааны шилжүүлэлт нь улсын секторын нэгдэл болно. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо, Боловсролын хэлтсийн харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрхүү нэгдлийн оролцогч талуудын аль нэг нь үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.

ҮЖ57. Энэ жишээнд Боловсролын хэлтэс нь дараах зүйлсийг олж авна:


(а) Бага сургуулийн хоол тэжээлийн үйл ажиллагааны хувьд бүрэн эрх;

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (б) Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - (в) Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ58. Энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Боловсролын хэлтэс нь Бага сургуулийн хоол тэжээлийн үйл ажиллагааны хяналтыг олж авсан гэж дүгнэсэн. Боловсролын хэлтэс нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ59. Боловсролын хэлтэс нь сайн дурын ажил гүйлгээгээр олж авч болох байсантай ижил эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид хандан нэвтрэх боломжтой болсон гэдгийг тус Боловсролын хэлтэс нь уг улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ тэмдэглэсэн; энэ нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлж болох юм.
- ҮЖ60. Энэхүү нэгдэл нь ерөнхий хяналтан доор хийгдсэн бөгөөд хяналт тавигч байгууллага болох Мужийн засаг захиргаа нь нэгдлийн нөхцөлд ямар нэг төлбөрийг тусгайлан заагаагүй учраас уг улсын секторын нэгдэлд төлбөр төлөлтийг тусган оруулахгүй гэдгийг Боловсролын хэлтэс нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Иймээс төлбөр төлөхгүй байх нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлж болох боловч энэ нь дангаараа дүгнэлтийн шинжтэй болохгүй бөгөөд бусад хүчин зүйлсийг мөн харгалзан үзэх шаардлагатай байдаг.
- ҮЖ61. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Боловсролын хэлтэс нь уг улсын секторын нэгдлийг ерөнхий хяналтан доор хийсэн гэдгийг онцлон тэмдэглэсэн. Энэхүү нэгдлийг Мужийн засаг захиргаа тулган хэрэгжүүлсэн. Энэ нь уг нэгдлийг хийх эсэх эцсийн шийдвэр болон нэгдлийн нөхцлийг тухайн хяналт тавигч байгууллага болох Мужийн засаг захиргаа тодорхойлдог гэсэн нотолгоо болно. Мөн энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор хангана.
- ҮЖ62. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Боловсролын хэлтэс нь энэхүү улсын секторын нэгдлийг нийлүүлэлт гэж ангилах хэрэгтэй гэж үзсэн. Энэхүү шийдвэрийг гаргах үедээ, уг улсын секторын нэгдлийг ерөнхий хяналтан доор хийсэн нь тухайн нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл болно гэж үзсэн.

Жишээ 6: Улсын секторын байгууллагыг ашгийн төлөө бус байгууллагатай нэгтгэх

ҮЖ63. Улсын секторын байгууллагыг ижил төрлийн үйлчилгээ үзүүлдэг, ашгийн төлөө бус байгууллагатай нэгтгэх нэгдлийг дараах схемд харуулав.



ҮЖ64. Энэ жишээнд, сувилагчийн үйлчилгээ үзүүлдэг буяны байгууллага болох К ашгийн төлөө бус байгууллага нь олон нийтэд үзүүлж буй үйлчилгээгээ сайжруулахын тулд Эрүүл мэндийн хэлтэст сайн дураар нэгдэхийг зөвшөөрсөн. К ашгийн төлөө бус байгууллагын үйл ажиллагааг Эрүүл мэндийн хэлтсийн адилтгах үйл ажиллагаатай нэгтгэсэн. Уг нэгдлээс өмнө Эрүүл мэндийн хэлтэс нь К ашгийн төлөө бус байгууллагад санхүүжилт олгодог байсан. К ашгийн төлөө бус байгууллагын хөрөнгө, өр төлбөрийн эрхийг шилжүүлэхдээ тус буяны байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн гаргасан зардлыг Эрүүл мэндийн хэлтэс хариуцна.

ҮЖ65. Эрүүл мэндийн хэлтэс ба К ашгийн төлөө бус байгууллагын нэгдэл нь улсын секторын нэгдэл юм. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Эрүүл мэндийн хэлтсийн харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрээр үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.

ҮЖ66. Энэ жишээнд Эрүүл мэндийн хэлтэс нь дараах зүйлсийг олж авна:

- (а) К ашгийн төлөө бус байгууллага болон түүний үйл ажиллагааны хувьд бүрэн эрх;
- (б) Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
- (в) Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.

ҮЖ67. Энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Эрүүл мэндийн хэлтэс нь К ашгийн төлөө бус байгууллагын хяналтыг олж авсан гэж дүгнэсэн. Эрүүл

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ


мэндийн хэлтэс нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.

- ҮЖ68. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Эрүүл мэндийн хэлтэс нь Эрүүл мэндийн хэлтэс ба К ашгийн төлөө бус байгууллагын хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүсэхгүй гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлт ба худалдан авалтын аль алинтай нийцэж байна.
- ҮЖ69. Үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгаагүй гэдгийг Эрүүл мэндийн хэлтэс нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Хэдийгээр Эрүүл мэндийн хэлтэс нь итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд төлбөр төлж байгаа боловч энэ нь К ашгийн төлөө бус байгууллагын цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд тэдэнд олгож буй нөхөн төлбөр биш, харин нэгдлийг хийхийн тулд гаргасан өртөг зардлын нөхөлт юм. К ашгийн төлөө бус байгууллага нь Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн Зөвлөлтэй боловч тэдгээр хүмүүс нь уг үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд эрхгүй байдаг. Энэ нь К ашгийн төлөө бус байгууллагын цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй тал байхгүй (өөрөөр хэлбэл, К ашгийн төлөө бус байгууллагын тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоо бүхий хуучин эзэд байхгүй) гэдгийг илэрхийлнэ. Энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн үг юм. Энэ жишээний хувьд, нийлүүлэлтийн зорилго нь олон нийтэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах явдал гэдгээр үүнийг батлан харуулна.
- ҮЖ70. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Эрүүл мэндийн хэлтэс нь уг улсын секторын нэгдлийг сайн дураар хийсэн гэдгийг онцлон тэмдэглэсэн. Иймээс эдгээр үзүүлэлтүүд нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх аливаа нотолгоогоор хангахгүй юм.
- ҮЖ71. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Эрүүл мэндийн хэлтэс нь энэхүү улсын секторын нэгдлийг нийлүүлэлт гэж ангилах хэрэгтэй гэж үзсэн. Энэхүү шийдвэрийг гаргахдаа Эрүүл мэндийн хэлтэс нь үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн хувьд бүрэн эрхтэй тал байхгүй учраас төлбөр төлөхгүй байгаа нь уг нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл болно гэж дүгнэсэн. Энэ жишээнд, Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн Зөвлөл нь олон нийтэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахын тулд тухайн үйл ажиллагааны хяналтыг сайн дураараа өгч байгаа нь энэхүү үзэл санааг дахин бататгаж байна.

### *Жишээ 7: Засгийн газрын түвшнүүдийн хооронд үйл ажиллагааг шилжүүлэх*

- ҮЖ72. Засгийн газрын түвшнүүдийн хоорондох үйл ажиллагааны шилжүүлэлтийг дараах схемд үлгэрчлэн харуулсан.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ



ҮЖ73. Энэ жишээнд Төв засгийн газар нь нийгмийн зарим үйлчилгээний эрх, үүргийг Мужийн засаг захиргаанд шилжүүлэх бодлого баримталсан. Үүний үр дүнд, Төв засгийн газар нь орон сууцны тусламж үйлчилгээ үзүүлдэг Л үйл ажиллагааг Төв засгийн газрын Нийгмийн үйлчилгээний хэлтсээс Мужийн засаг захиргааны Нийгмийн үйлчилгээний хэлтэст шилжүүлэхийг санал болгосон. Мужийн засаг захиргаа нь уг бодлогыг дэмжиж, Л үйл ажиллагааг хүлээн авахыг зөвшөөрсөн. Л үйл ажиллагаа нь 1,000 ТН<sup>2</sup>-ийн цэвэр хөрөнгөтэй. Мужийн засаг захиргаанаас Төв засгийн газарт ямар нэгэн төлбөр шилжүүлэхгүй. Гэвч уг шилжүүлэлтийн гэрээнд зааснаар, Мужийн засаг захиргаа нь хамгийн багадаа 10 жилийн хугацаанд орон сууцны тусламж үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх үүрэг хүлээсэн. Л үйл ажиллагаа нь гарсан бүх зардлаа үйлчилгээний төлбөрөөрөө нөхдөггүй; иймээс Мужийн засаг захиргаа нь уг дутагдлыг нөхөхийн тулд нөөцөөр хангах үүрэг хүлээнэ. Шилжүүлэлтийн дараа, Мужийн засаг захиргаа нь уг үйл ажиллагааг өөрийн бусад үйл ажиллагаатай хожим нийлүүлэх, ингэснээр хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцааг арилгахаар төлөвлөж байгаа боловч одоогоор Л үйл ажиллагааг бие даасан байгууллага байдлаар ажиллуулж (өөрөөр хэлбэл, Мужийн засаг захиргаа ба Л үйл ажиллагааны хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаатай) байна.

ҮЖ74. Л үйл ажиллагааны шилжүүлэлт нь Мужийн засаг захиргааны санхүүгийн тайлан болон Мужийн засаг захиргааны Нийгмийн үйлчилгээний хэлтсийн санхүүгийн тайлангийн аль алинд тайлагнах шаардлагатай улсын секторын нэгдэл юм. Шаардлагатай шинжилгээ нь уг хоёр байгууллагын хувьд ижил байх учраас энэ жишээнд тэрхүү хоёр байгууллагыг илэрхийлэхийн тулд Мужийн засаг захиргаа гэсэн хэллэгийг ашигласан.

<sup>2</sup> Энэ жишээнд мөнгөн дүнг “тооцооны нэгж” (ТН)-гэж илэрхийлсэн.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- ҮЖ75. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Мужийн засаг захиргааны харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрээр үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ76. Энэ жишээнд Мужийн засаг захиргаа нь дараах зүйлсийг олж авна:
- (а) Л үйл ажиллагааны хувьд бүрэн эрх;
  - (б) Л үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - (в) Л үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ77. Энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Мужийн засаг захиргаа нь Л үйл ажиллагааны хяналтыг олж авсан гэж дүгнэсэн. Мужийн засаг захиргаа нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ78. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Мужийн засаг захиргаа нь Мужийн засаг захиргаа ба Л үйл ажиллагааны хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүснэ гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай нийцэхгүй юм.
- ҮЖ79. Үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгаагүй гэдгийг Мужийн засаг захиргаа нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Гэвч уг шилжүүлэлтийн гэрээнд зааснаар, Мужийн засаг захиргаа нь тусламж үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх үүрэг хүлээсэн. Л үйл ажиллагаа нь гарсан бүх зардлаа үйлчилгээний төлбөрөөрөө нөхдөггүй тул Мужийн засаг захиргаа нь уг дутагдлыг нөхөхийн тулд хэрэгцээт нөөцөөр хангах шаардлагатай болно. Тохиролцсон 10 жилийн хугацаанд үйлчилгээг үзүүлэх өртөг зардал нь тухайн хүлээн авсан цэвэр хөрөнгийн үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү болох магадлалтай гэж Мужийн засаг захиргаа үзэж байна. Иймээс зах зээлийн оролцогч нь Л үйл ажиллагааны бодит үнэ цэнийг (10 жилийн хугацаанд үйлчилгээ үзүүлэх үүргийн хамт) тэг (0) гэж тооцоолно гэж үзэж байна. Хэдийгээр ямар нэг төлбөр шилжүүлээгүй боловч энэ нь уг нэгдлийн бодит үнэ цэнийг тусгана. Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд нь тухайн нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх ямар нэг нотолгоогоор хангахгүй гэж Мужийн засаг захиргаа дүгнэсэн.
- ҮЖ80. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Мужийн засаг захиргаа нь уг улсын секторын нэгдлийг сайн дураар хийсэн гэдгийг онцлон тэмдэглэсэн. Иймээс эдгээр үзүүлэлтүүд нь уг

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх аливаа нотолгоогоор хангахгүй юм.

ҮЖ81. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Мужийн засаг захиргаа нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо байхгүй, иймээс энэхүү улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж ангилах хэрэгтэй гэж дүгнэсэн.

Жишээ 7-гийн хувилбар

ҮЖ82. Жишээ 7-д дурдсанаар, зах зээлийн оролцогч нь Л үйл ажиллагааны бодит үнэ цэнийг (10 жилийн хугацаанд үйлчилгээ үзүүлэх үүргийн хамт) тэг (0) гэж тооцоолно гэж Мужийн засаг захиргаа үзэж байна. Энэ нь төлбөр төлөхгүй байх шалтгаан юм. Харин энэ хувилбарт Л үйл ажиллагаа нь гарсан бүх зардлаа өөрийн үйлчилгээний төлбөрөөр нөхдөг гэж үзье. Иймээс зах зээлийн оролцогч нь Л үйл ажиллагааны бодит үнэ цэнийг (10 жилийн хугацаанд үйлчилгээ үзүүлэх үүргийн хамт) тэг (0)-ээс их гэж тооцоолно.


ҮЖ83. Эдгээр нөхцөл байдалд үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгаагүй байгаа нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор хангаж болох юм.

ҮЖ84. Уг улсын секторын нэгдлийн ангиллыг тодорхойлохдоо, Мужийн засаг захиргаа нь аль хүчин зүйл буюу зүйлс хамгийн чухал ач холбогдолтой болохыг авч үзсэн. Л үйл ажиллагааны хяналтыг Мужийн засаг захиргаа олж авсан, уг нэгдлээр түүний үйл ажиллагаануудыг Л үйл ажиллагааны холбогдох үйл ажиллагаануудтай нийлүүлээгүй нь тухайн нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйлс гэж Мужийн засаг захиргаа үзсэн. Энэ нь уг нэгдлийг худалдан авалт гэж ангилах хэрэгтэй гэдгийг илэрхийлнэ. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүд нь энэ ангиллыг дэмжиж баталгаажуулж байна; зөвхөн төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай байж болох юм гэдгийг илэрхийлж байна. Иймээс Мужийн засаг захиргаа нь энэхүү нэгдлийг худалдан авалт гэж ангилсан.

*Жишээ 8: Засгийн газрын түвшнүүдийн хоорондох худалдаа арилжааны байгууллагын шилжүүлэлт*

ҮЖ85. Засгийн газрын түвшнүүдийн хоорондох худалдаа арилжааны байгууллагын шилжүүлэлтийг дараах схемд үлгэрчлэн харуулсан.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ



- ҮЖ86. Энэ жишээнд Холбооны засгийн газар нь Н худалдаа арилжааны байгууллагыг М мужийн засаг захиргаанд шилжүүлэхийг зөвшөөрсөн. Энэхүү шилжүүлэлттэй холбоотойгоор М мужийн засаг захиргаа нь Холбооны засгийн газарт төлбөр төлнө. Уг нэгдлийн дараа М мужийн засаг захиргаа нь Н худалдаа арилжааны байгууллагыг харилцан хамааралгүй бие даасан байгууллага байдлаар ажиллуулна.
- ҮЖ87. Н худалдаа арилжааны байгууллагын шилжүүлэлт нь улсын секторын нэгдэл юм. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо М мужийн засаг захиргааны харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрээр үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ88. Энэ жишээнд М мужийн засаг захиргаа нь дараах зүйлсийг олж авна:
- Н худалдаа арилжааны байгууллага ба түүний үйл ажиллагааны хувьд бүрэн эрх;
  - Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - Тэдгээр үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ89. Энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд М мужийн засаг захиргаа нь Н худалдаа арилжааны байгууллагын хяналтыг олж авсан гэж дүгнэсэн. М мужийн засаг захиргаа нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ90. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, М мужийн засаг захиргаа нь тус Мужийн засаг захиргаа ба Н худалдаа арилжааны байгууллагын хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүснэ гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай нийцэхгүй юм. Уг




## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

нэгдэл арилжааны шинж чанартай байгаа нь түүнийг худалдан авалт гэж үзэхэд хүргэнэ гэдгийг М мужийн засаг захиргаа бас тэмдэглэсэн.

- ҮЖ91. Үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгасан гэдгийг М мужийн засаг захиргаа нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд нь тухайн нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх ямар нэг нотолгоогоор хангахгүй гэж М мужийн засаг захиргаа дүгнэсэн.
- ҮЖ92. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, М мужийн засаг захиргаа нь уг улсын секторын нэгдлийг сайн дураар хийсэн гэдгийг онцлон тэмдэглэсэн. Иймээс эдгээр үзүүлэлтүүд нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх аливаа нотолгоогоор хангахгүй юм.
- ҮЖ93. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр М мужийн засаг захиргаа нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо байхгүй, иймээс энэхүү улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж ангилах хэрэгтэй гэж дүгнэсэн.

### Жишээ 9: Хувийн хэвшлийн үйл ажиллагааг худалдан авах

- ҮЖ94. Улсын секторын байгууллага нь хувийн хэвшлийн үйл ажиллагааг худалдан авч буйг дараах схемд үлгэрчлэн харуулсан.



- ҮЖ95. Энэ жишээнд Төв засгийн газар нь П үйл ажиллагааг О компаниас худалдан авсан. Төв засгийн газар нь П үйл ажиллагааны зах зээлийг төлсөн бөгөөд О компани нь сайн дурын үндсэн дээр оролцсон. Худалдан авалтын дараа П үйл ажиллагааг харилцан хамааралгүй бие даасан байгууллага байдлаар эрхлэн явуулна.
- ҮЖ96. П үйл ажиллагааны худалдан авалт нь улсын секторын нэгдэл юм. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Төв засгийн газрын харгалзан үзэх хамгийн эхний асуулт

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

бол уг нэгдлийн үр дүнд тэрээр үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.

- ҮЖ97. Энэ жишээнд Төв засгийн газар нь дараах зүйлсийг олж авна:
- (а) П үйл ажиллагааны хувьд бүрэн эрх;
  - (б) П үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - (в) П үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ98. Энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Төв засгийн газар нь П үйл ажиллагааны хяналтыг олж авсан гэж дүгнэсэн. Төв засгийн газар нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ99. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Төв засгийн газар нь тус Төв засгийн газар ба П үйл ажиллагааны хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүснэ гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай нийцэхгүй юм. Уг нэгдэл арилжааны шинж чанартай байгаа нь түүнийг худалдан авалт гэж үзэхэд хүргэнэ гэдгийг Төв засгийн газар бас тэмдэглэсэн.
- ҮЖ100. Үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгасан гэдгийг Төв засгийн газар нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд нь тухайн нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх ямар нэг нотолгоогоор хангахгүй гэж Төв засгийн газар дүгнэсэн.
- ҮЖ101. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Төв засгийн газар нь уг улсын секторын нэгдлийг сайн дураар хийсэн гэдгийг онцлон тэмдэглэсэн. Иймээс эдгээр үзүүлэлтүүд нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх аливаа нотолгоогоор хангахгүй юм.
- ҮЖ102. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Төв засгийн газар нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо байхгүй, иймээс энэхүү улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж ангилах хэрэгтэй гэж дүгнэсэн.


## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

### Жишээ 9-ийн Хувилбар

- ҮЖ103. Жишээ 9-ийн хувьд О компани нь тухайн ажил гүйлгээнд сайн дурын үндсэн дээр оролцсон. Харин энэ хувилбарт Төв засгийн газар нь албадан худалдан авах байдлаар П үйл ажиллагааг төрийн мэдэлд авсан гэж үзье. Гэхдээ уг худалдан авалтыг П үйл ажиллагааны зах зээлийн үнээр хийсэн.
- ҮЖ104. Сайн дурын ажил гүйлгээнээс албадан худалдан авалт болгох өөрчлөлт нь хяналтын үнэлгээ буюу төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдэд нөлөөлөхгүй юм.
- ҮЖ105. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Төв засгийн газар нь О компани сайн дурын үндсэн дээр оролцоогүй гэдгийг онцлон тэмдэглэсэн. Төв засгийн газар (нэгдлийн оролцогч тал) уг улсын секторын нэгдлийг О компанид тулган хэрэгжүүлэх чадвар боломжтой байдал нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор хангана.
- ҮЖ106. Иймээс Төв засгийн газар нь уг улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж ангилсан.

### Жишээ 10: Тохиролцоот худалдан авалт

- ҮЖ107. Улсын секторын байгууллагын хийсэн тохиролцоот худалдан авалтыг дараах схемд үлгэрчлэн харуулсан.



- ҮЖ108. Энэ жишээнд Р нутгийн захиргаа нь С компаниас Т үйл ажиллагааг тохиролцоот худалдан авалтаар авсан. С компани нь өөрийн бусад үйл ажиллагаандаа зориулан мөнгөн хөрөнгө олж авахын тулд Т үйл ажиллагааг хурдан борлуулахыг эрмэлзэж байгаа бөгөөд эрт борлуулахын тулд Т үйл ажиллагааг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдахад бэлэн байна. Энэхүү тохиролцоот худалдан авалт хийхдээ С компани нь сайн дурын үндсэн дээр оролцсон. Уг худалдан авалтын дараа, Р нутгийн захиргаа нь Т үйл ажиллагааг харилцан хамааралгүй бие даасан байгууллага байдлаар эрхлэн явуулна.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- ҮЖ109. Т үйл ажиллагааны тохиролцоот худалдан авалт нь улсын секторын нэгдэл юм. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Р нутгийн захиргааны харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрээр үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ110. Энэ жишээнд Р нутгийн захиргаа нь дараах зүйлсийг олж авна:
- (а) Т үйл ажиллагааны хувьд бүрэн эрх;
  - (б) Т үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - (в) Т үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ111. Энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Р нутгийн захиргаа нь Т үйл ажиллагааны хяналтыг олж авсан гэж дүгнэсэн. Р нутгийн захиргаа нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ112. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Р нутгийн захиргаа нь тус Р нутгийн захиргаа ба Т үйл ажиллагааны хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүснэ гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай нийцэхгүй юм. Уг нэгдэл (хэдийгээр төлсөн үнэ нь Т үйл ажиллагааны зах зээлийн үнээс бага байлаа ч гэсэн) арилжааны шинж чанартай байгаа нь түүнийг худалдан авалт гэж үзэхэд хүргэнэ гэдгийг Р нутгийн захиргаа бас тэмдэглэсэн.
- ҮЖ113. Хэдийгээр зах зээлийн үнээс бага үнэтэй боловч үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгасан гэдгийг Р нутгийн захиргаа нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. С компани нь хурдан борлуулахын тулд бага үнийг сайн дураар хүлээн зөвшөөрсөн бөгөөд уг төлсөн төлбөрийн зорилго нь Т үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд хүлээн зөвшөөрөхөд бэлэн байсан төлбөрийн түвшнийг С компанид олгох явдал юм. Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд нь тухайн нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх ямар нэг нотолгоогоор хангахгүй гэж Р нутгийн захиргаа дүгнэсэн.
- ҮЖ114. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Р нутгийн захиргаа нь уг улсын секторын нэгдлийг сайн дураар хийсэн гэдгийг онцлон тэмдэглэсэн. Иймээс эдгээр үзүүлэлтүүд нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх аливаа нотолгоогоор хангахгүй юм.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

ҮЖ115. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Р нутгийн захиргаа нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо байхгүй, иймээс энэхүү улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж ангилах хэрэгтэй гэж дүгнэсэн.

### Жишээ 10-ын Хувилбар

ҮЖ116. Жишээ 10-ын хувьд С компани нь тухайн ажил гүйлгээнд сайн дурын үндсэн дээр оролцсон. Харин энэ хувилбарт Р нутгийн захиргаа нь албадан худалдан авалтаар Т үйл ажиллагааг зогсоосон гэж үзье. Гэхдээ уг худалдан авалтыг Т үйл ажиллагааны зах зээлийн үнээс бага үнээр хийсэн. С компани нь Т үйл ажиллагааг зах зээлийн үнээс бага үнээр сайн дураараа борлуулахгүй байсан.

ҮЖ117. Сайн дурын ажил гүйлгээнээс албадан худалдан авалт болгох өөрчлөлт нь хяналтын үнэлгээнд нөлөөлөхгүй юм.

ҮЖ118. Үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгасан гэдгийг Р нутгийн захиргаа нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Гэвч төлбөрийн хэмжээ нь С компанийн сайн дураараа хүлээн зөвшөөрөх дүнгээс бага байсан. Иймээс эдгээр үзүүлэлтүүд нь тухайн нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэсэн багахан нотолгоогоор хангах бөгөөд бусад хүчин зүйлсэд илүү их ач холбогдол өгнө.


ҮЖ119. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Р нутгийн захиргаа нь С компани сайн дурын үндсэн дээр оролцоогүй гэдгийг онцлон тэмдэглэсэн. Р нутгийн захиргаа (нэгдлийн оролцогч тал) уг улсын секторын нэгдлийг С компанид тулган хэрэгжүүлэх чадвар боломжтой байдал нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор хангана.

ҮЖ120. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Р нутгийн захиргаа нь уг улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж ангилсан.

### Жишээ 11: Хандивласан үйл ажиллагаа

ҮЖ121. Хандивласан үйл ажиллагааг улсын секторын байгууллага хүлээн авалтыг дараах схемд үлгэрчлэн харуулсан.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ



- ҮЖ122. Энэ жишээнд, боловсролын үйлчилгээ үзүүлдэг буяны байгууллага болох У ашгийн төлөө бус байгууллага нь Ф үйл ажиллагаа буюу сургуулиа Боловсролын яаманд сайн дурын үндсэн дээр үнэ төлбөргүй шилжүүлсэн. Ингэж шилжүүлэх нь олон түмэнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах ба уг сургуулийн зорилгод нийцнэ гэж үзсэн тул У ашгийн төлөө бус байгууллага нь уг сургуулийг шилжүүлсэн.
- ҮЖ123. Ф үйл ажиллагааны хандивлалт нь улсын секторын нэгдэл юм. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Боловсролын яамны харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрээр үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ124. Энэ жишээнд Боловсролын яам нь дараах зүйлсийг олж авна:
- (а) Ф үйл ажиллагааны хувьд бүрэн эрх;
  - (б) Ф үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - (в) Ф үйл ажиллагаан дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн үйл ажиллагааны хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ125. Боловсролын яам нь энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Ф үйл ажиллагааны хяналтыг олж авсан гэж дүгнэсэн. Боловсролын яам нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ126. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Боловсролын яам нь уг нэгдэл арилжааны шинж чанартай байгаа бөгөөд энэ нь түүнийг худалдан авалт гэж үзэхэд хүргэнэ гэдгийг тэмдэглэсэн.
- ҮЖ127. Үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгаагүй гэдгийг Боловсролын яам нь

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ


төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Гэвч үүний шалтгаан нь У ашгийн төлөө бус байгууллага тэдгээр эрхийг сайн дураар өгсөн явдал юм. Энэ нөхцөл байдал нь тохиролцоот худалдан авалттай ижил төсөөтэй юм. Тохиролцоот худалдан авалтын үед борлуулагч нь өөрийн хэрэгцээ шаардлагад нийцэж байх тохиолдолд тухайлбал, хурдан борлуулах боломжтой болохын тулд зах зээлийн түвшнээс бага үнийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байж болох юм. Хандивласан үйл ажиллагааны хувьд түүний хуучин эзэн нь өөрийн зохистой гэж үзсэн оролцогч нөгөө талдаа тухайн үйл ажиллагааг үнэ төлбөргүй шилжүүлэхэд бэлэн байдаг. Энэ жишээнд У ашгийн төлөө бус байгууллага нь олон нийтэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах учраас Ф үйл ажиллагааг Боловсролын яаманд шилжүүлэн өгөхөд бэлэн байна. Иймээс төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд нь тухайн нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх ямар нэг нотолгоогоор хангахгүй гэж Боловсролын яам дүгнэсэн.

ҮЖ128. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Боловсролын яам нь уг улсын секторын нэгдлийг сайн дураар хийсэн гэдгийг онцлон тэмдэглэсэн. Иймээс эдгээр үзүүлэлтүүд нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх аливаа нотолгоогоор хангахгүй юм.

ҮЖ129. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Боловсролын яам нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо байхгүй, иймээс энэхүү улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж ангилах хэрэгтэй гэж дүгнэсэн.

*Жишээ 12: Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг төрийн өмчид авах – Албадан хураах*

ҮЖ130. Улсын секторын байгууллага нь албадан хураах замаар хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг төрийн өмчид авч байгааг дараах схемд үлгэрчлэн харуулсан.



ҮЖ131. Энэ жишээнд Төв засгийн газар нь хууль тогтоомжийн дагуу Х компанийг төрийн өмчид авсан. Төв засгийн газар нь Х компанийн хувьцаа эзэмшигчдэд ямар нэг төлбөр төлөөгүй. Уг худалдан авалтын дараа Х

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- компанийг харилцан хамааралгүй бие даасан байгууллага байдлаар ажиллуулна.
- ҮЖ132. Х компанийг төрийн өмчид авсан нь улсын секторын нэгдэл юм. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Төв засгийн газрын харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрээр үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ133. Энэ жишээнд Төв засгийн газар нь дараах зүйлсийг олж авна:
- (а) Х компанийн хувьд бүрэн эрх;
  - (б) Х компани дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - (в) Х компани дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн компанийн хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ134. Төв засгийн газар нь энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Х компанийн хяналтыг олж авсан гэж дүгнэсэн. Төв засгийн газар нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ135. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Төв засгийн газар нь тус Төв засгийн газар ба Х компанийн хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүснэ гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай нийцэхгүй юм. Х компани дахь хуучин хувьцаа эзэмшигчдийн эрхийг үгүй болгосноор уг нэгдэл арилжааны шинж чанартай байгаа нь түүнийг худалдан авалт гэж үзэхэд хүргэнэ гэдгийг Төв засгийн газар бас тэмдэглэсэн.
- ҮЖ136. Үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгаагүй гэдгийг Төв засгийн газар нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Гэвч Х компанийн хуучин хувьцаа эзэмшигчид эрхээ албадан хураалгасан нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо болно. Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд нь тухайн нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх ямар нэг нотолгоогоор хангахгүй гэж Төв засгийн газар дүгнэсэн.
- ҮЖ137. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Төв засгийн газар нь Х компани сайн дурын үндсэн дээр оролцоогүй гэдгийг онцлон тэмдэглэсэн. Төв засгийн газар (нэгдлийн оролцогч тал) уг улсын секторын нэгдлийг Х компанид тулган хэрэгжүүлэх чадвар




## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

боломжтой байдал нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор хангана.

ҮЖ138. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Төв засгийн газар нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо байхгүй, иймээс энэхүү улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж ангилах хэрэгтэй гэж дүгнэсэн.

*Жишээ 13: Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг төрийн өмчид авах – “Авралын арга хэмжээ”*

ҮЖ139. Улсын секторын байгууллага нь авралын арга хэмжээ байдлаар хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг төрийн өмчид авч байгааг дараах схемд үлгэрчлэн харуулсан.



ҮЖ140. Энэ жишээнд Ц мужийн засаг захиргаа нь авралын арга хэмжээний үр дүнд Ч компанийг хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид авсан. Төрийн өмчид авахаас өмнө Ч компани нь санхүүгийн хямралд орсон байсан. Ц мужийн засаг захиргаа нь Ч компанийн хувьцаа эзэмшигчдэд ямар нэгэн төлбөр төлөөгүй боловч Ч компанийн цэвэр өр төлбөрийг хариуцсан. Энэ худалдан авалтын дараа Ч компанийг харилцан хамааралгүй бие даасан байгууллага байдлаар ажиллуулна.

ҮЖ141. Ч компанийг төрийн өмчид авсан нь улсын секторын нэгдэл юм. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Ц мужийн засаг захиргааны харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрээр үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.


ҮЖ142. Энэ жишээнд Ц мужийн засаг захиргаа нь дараах зүйлсийг олж авна:

- (а) Ч компанийн хувьд бүрэн эрх;
- (б) Ч компани дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- (в) Ч компани дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн компанийн хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ143. Ц мужийн засаг захиргаа нь энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Ч компанийн хяналтыг олж авсан гэж дүгнэсэн. Ц мужийн засаг захиргаа нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ144. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Ц мужийн засаг захиргаа нь тус Мужийн засаг захиргаа ба Ч компанийн хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүснэ гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай нийцэхгүй юм. Ч компанийн цэвэр өр төлбөрийг хариуцсанаар уг нэгдэл арилжааны шинж чанартай байгаа нь түүнийг худалдан авалт гэж үзэхэд хүргэнэ гэдгийг Ц мужийн засаг захиргаа бас тэмдэглэсэн.
- ҮЖ145. Үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгаагүй гэдгийг Ц мужийн засаг захиргаа нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Гэвч Ч компани нь цэвэр өр төлбөртэй бөгөөд уг нэгдлийн нэг хэсэг байдлаар Ц мужийн засаг захиргаа нь түүнийг хариуцаж байна. Төлбөр төлөөгүй нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх биш, харин Ч компанийн бодит үнэ цэнийг тусган харуулж байна. Төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд нь тухайн нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх ямар нэг нотолгоогоор хангахгүй гэж Ц мужийн засаг захиргаа дүгнэсэн.
- ҮЖ146. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Ц мужийн засаг захиргаа нь Ч компани сайн дурын үндсэн дээр оролцоогүй гэдгийг онцлон тэмдэглэсэн. Ц мужийн засаг захиргаа (нэгдлийн оролцогч тал) уг улсын секторын нэгдлийг Ч компанид тулган хэрэгжүүлэх чадвар боломжтой байдал нь уг нэгдэл худалдан авалтын эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор хангана.
- ҮЖ147. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Ц мужийн засаг захиргаа нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо байхгүй, иймээс энэхүү улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж ангилах хэрэгтэй гэж дүгнэсэн.
- Жишээ 14: Ашгийн төлөө бус байгууллагыг төрийн өмчид авах – “Авралын арга хэмжээ”*
- ҮЖ148. Улсын секторын байгууллага нь авралын арга хэмжээ байдлаар ашгийн төлөө бус байгууллагыг төрийн өмчид авч байгааг дараах схемд үлгэрчлэн харуулсан.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ



- ҮЖ149. Энэ жишээнд Ш хот нь сайн дурын авралын арга хэмжээний үр дүнд Э ашгийн төлөө бус байгууллага (буяны байгууллага)-ыг төрийн өмчид авсан. Төрийн өмчид авахаас өмнө Э ашгийн төлөө бус байгууллага нь санхүүгийн хямралд орсон бөгөөд Ш хотоос дэмжлэг хүсэж хандсан. Ш хот нь Э ашгийн төлөө бус байгууллагын цэвэр өр төлбөрийг хариуцсан. Энэ худалдан авалтын дараа Э ашгийн төлөө бус байгууллагыг харилцан хамааралгүй бие даасан байгууллага байдлаар ажиллуулна.
- ҮЖ150. Э ашгийн төлөө бус байгууллагыг төрийн өмчид авсан нь улсын секторын нэгдэл юм. Үүнийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Ш хотын харгалзан үзэх хамгийн эхний асуулт бол уг нэгдлийн үр дүнд тэрээр үйл ажиллагааны хяналтыг олж авсан эсэх юм.
- ҮЖ151. Энэ жишээнд Ш хот нь дараах зүйлсийг олж авна:
- (а) Э ашгийн төлөө бус байгууллагын хувьд бүрэн эрх;
  - (б) Э ашгийн төлөө бус байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг буюу тэрхүү өгөөжийг хүртэх эрх; ба
  - (в) Э ашгийн төлөө бус байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэхийн тулд тухайн компанийн хувьд өөрийн бүрэн эрхийг ашиглах чадвар боломж.
- ҮЖ152. Ш хот нь энэхүү улсын секторын нэгдлийн үр дүнд Э ашгийн төлөө бус байгууллагын хяналтыг олж авсан гэж дүгнэсэн. Ш хот нь энэхүү нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграф дахь заавар удирдамжийг харгалзан үзнэ.
- ҮЖ153. Улсын секторын нэгдлийн эдийн засгийн мөн чанарыг харгалзан үзэхдээ, Ш хот нь тус Ш хот ба Э ашгийн төлөө бус байгууллагын хооронд хяналт тавигч байгууллага/хяналтанд буй байгууллагын харилцаа энэхүү нэгдлээр үүснэ гэдгийг тэмдэглэсэн. Энэ нь нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай нийцэхгүй юм. Э ашгийн төлөө бус байгууллагын цэвэр өр

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

төлбөрийг хариуцсанаар уг нэгдэл арилжааны шинж чанартай байгаа нь түүнийг худалдан авалт гэж үзэхэд хүргэнэ гэдгийг Ш хот бас тэмдэглэсэн.

- ҮЖ154. Үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн эрхийг өгсөний хариуд борлуулагчид нөхөн төлбөр болгон олгох санаа зорилго бүхий төлбөр төлөлтийг энэхүү улсын секторын нэгдэлд тусгаагүй гэдгийг Ш хот нь төлбөртэй холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ тэмдэглэсэн. Яагаад гэвэл, Э ашгийн төлөө бус байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь цэвэр хөрөнгийн хувьд эрхгүй тул түүний цэвэр хөрөнгийн хувьд эрхтэй тал байхгүй (өөрөөр хэлбэл, хуучин эзэд байхгүй) юм. Энэ нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоогоор ихэвчлэн хангадаг. Гэвч Э ашгийн төлөө бус байгууллага нь цэвэр өр төлбөртэй бөгөөд уг нэгдлийн нэг хэсэг байдлаар Ш хот нь түүнийг хариуцаж байна. Цэвэр өр төлбөрийг хариуцсанаар Ш хот нь тэрхүү өр төлбөрийг барагдуулах үүрэг хариуцлагаас Э ашгийн төлөө бус байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг чөлөөлж байна, энэ нь төлбөр төлөхтэй адил утгатай юм. Иймээс төлбөртэй холбоотой үзүүлэлтүүд нь тухайн нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх ямар нэг нотолгоогоор хангахгүй гэж Ш хот дүгнэсэн.
- ҮЖ155. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэх үедээ, Ш хот нь Э ашгийн төлөө бус байгууллага уг нэгдлийг сайн дурын үндсэн дээр өөрөө санаачилсан гэдгийг онцлон тэмдэглэсэн. Шийдвэр гаргах үйл явцтай холбоотой үзүүлэлтүүд нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэдгийг илэрхийлэх аливаа нотолгоогоор хангахгүй гэж Ш хот дүгнэсэн.
- ҮЖ156. Эдгээр хүчин зүйлсийг хамтад нь авч үзсэнээр Ш хот нь уг нэгдэл нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанартай гэсэн нотолгоо байхгүй, иймээс энэхүү улсын секторын нэгдлийг худалдан авалт гэж ангилах хэрэгтэй гэж дүгнэсэн.

### Нийлүүлэлтийн тайлагнал

#### Нэгдэгч үйл ажиллагаануудын хоорондох ажил гүйлгээг устгаж цэвэрлэх – Зээл

*УСНББОУС 40-ийн 22, МЗУ51-МЗУ52-р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

- ҮЖ157. Ерөнхий хяналтанд байдаггүй нэгдэгч хоёр үйл ажиллагааны хоорондох зээлийг устгаж цэвэрлэх үйл явцыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.
- ҮЖ158. 20Х5 оны 6 дугаар сарын 30-нд А нэгдэгч үйл ажиллагаа (АНҮА) ба Б нэгдэгч үйл ажиллагаа (БНҮА)-ны нийлүүлэлтээр Үр дүнгийн байгууллага (ҮБ)-ыг үүсгэн байгуулсан. Дөрвөн жилийн өмнө АНҮА нь 10 жилийн хугацаатай, тогтмол хүүтэй, 250 ТН-ийн зээлийг БНҮА-д олгосон байсан. Зээлийн үндсэн дүнг хугацааны эцэст, хүүг жил бүр төлнө.

- ҮЖ159. БНҮА нь сүүлийн үед санхүүгийн хүндрэлд орсон бөгөөд уг нийлүүлэх өдөр хүүний төлөгдөөгүй өр төлбөртэй байсан. Нийлүүлэх өдрөөр түүний санхүүгийн тайлан дахь уг санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ (зээлийн хорогдуулсан өртөг) нь 260ТН байв.
- ҮЖ160. Төлөгдөөгүй өр төлбөрийн үлдэгдэл ба БНҮА-ны санхүүгийн хүндрэлтэй байдлыг харгалзан АНҮА нь тухайн зээлийн үнэ цэнийг бууруулсан. Нийлүүлэх өдрөөр түүний санхүүгийн тайлан дахь уг санхүүгийн хөрөнгө (зээл)-ийн дансны үнэ нь 200ТН байв.
- ҮЖ161. Нийлүүлэх өдөр ҮБ нь АНҮА-аас авсан санхүүгийн хөрөнгө ба БНҮА-аас хариуцан хүлээсэн санхүүгийн өр төлбөрийг устган цэвэрлэж, уг зээлтэй холбоотой санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн дансны үнүүдийн хоорондох зөрүү болох 60ТН-ээр цэвэр хөрөнгө/өмчийн кредит бүрэлдэхүүн хэсэгт тусгасан.

**Нэгдэгч үйл ажиллагаануудын хоорондох ажил гүйлгээг устгаж цэвэрлэх – Шилжүүлэг**

*УСНББОУС 40-ийн 22, МЗУ51-МЗУ52-р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

- ҮЖ162. Ерөнхий хяналтанд байдаггүй нэгдэгч хоёр үйл ажиллагааны хоорондох шилжүүлгийг устгаж цэвэрлэх үйл явцыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.
- ҮЖ163. 20Х9 оны 6 дугаар сарын 30-нд А нэгдэгч үйл ажиллагаа (АНҮА) ба Б нэгдэгч үйл ажиллагаа (БНҮА) болох засгийн газрын хоёр агентлагийн нийлүүлэлтээр Үр дүнгийн байгууллага (ҮБ)-ыг үүсгэн байгуулсан. 20Х9 оны 01 дүгээр сарын 01-нд АНҮА нь зөвшөөрөгдсөн тооны сургалт явуулахад ашиглах 700 ТН-ийн буцалтгүй тусламжийг БНҮА-д олгосон.
- ҮЖ164. Хийгдээгүй сургалтын тоогоор хувь тэнцүүлж, уг буцалтгүй тусламжийг буцаан төлөх нөхцөлтэй. Нийлүүлэх өдрөөр БНҮА нь тохиролцсон сургалтын тооны тэн хагастай тэнцэх сургалтыг явуулсан бөгөөд өөрийн гүйцэтгэлийн үүргийн хувьд 350 ТН-ийн өр төлбөрийг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн. Өөрийн өмнөх туршлагад үндэслэн АНҮА нь БНҮА уг сургалтыг явуулахгүй байхаас явуулах нь илүү их магадлалтай гэж үзсэн. Иймээс мөнгө хөрөнгийг АНҮА-д буцаан өгөх магадлал багатай байсан бөгөөд АНҮА нь уг буцалтгүй тусламжийн хувьд хөрөнгө хүлээн зөвшөөрөөгүй, харин 700 ТН-ийг бүгдийг нь зардал гэж тайлагнасан.
- ҮЖ165. Нийлүүлэх өдрөөр уг ажил гүйлгээг устгаж цэвэрлэсэн. Гаднын талуудад өгөх өглөг байхгүй. Үр дүнгийн байгууллага нь 350 ТН-ийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөөгүй, харин энэ дүнг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн.

**Нийлүүлэлтийн хувьд уг үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд нэгдэгч үйл ажиллагаануудын тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг тохируулах**

*УСНББОУС 40-ийн 26-27, 36-р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

- ҮЖ166. Нийлүүлэлтийн хувьд ерөнхий хяналтанд байдаггүй нэгдэгч үйл ажиллагаануудын тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг уг үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд тохируулах үйл явцыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.
- ҮЖ167. 20Х5 оны 10 дугаар сарын 01-нд А нэгдэгч үйл ажиллагаа (АНҮА) ба Б нэгдэгч үйл ажиллагаа (БНҮА) болох засгийн газрын хоёр агентлагийн нийлүүлэлтээр Үр дүнгийн байгууллага (ҮБ)-ыг үүсгэн байгуулсан. АНҮА нь УСНББОУС 17, *Үндсэн хөрөнгө*-д заасан өртгийн загвар ашигласнаар үндсэн хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өмнө нь мөрддөг байсан. БНҮА нь УСНББОУС 17-д заасан дахин үнэлгээний загвар ашигласнаар үндсэн хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өмнө нь мөрддөг байсан.
- ҮЖ168. ҮБ нь дахин үнэлгээний загвар ашигласнаар үндсэн хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрддөг. ҮБ нь АНҮА-ны өмнө нь хянаж байсан үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд хараат бус үнэлгээ хийлгэх гэж байна.
- ҮЖ169. АНҮА-ны өмнө нь хянаж байсан үндсэн хөрөнгийн зүйлсийн хараат бус үнэлгээ хийлгэсний дараа ҮБ нь уг үндсэн хөрөнгийн зүйлсийн дансны үнийг дараах байдлаар тохируулсан бөгөөд холбогдох бичилтийг цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүнд тусгасан:

<b>Хөрөнгийн анги</b>	<b>Дансны үнэ (ТН)</b>	<b>Үнэлгээ (ТН)</b>	<b>Тохируулга (ТН)</b>
Газар	17,623	18,410	787
Барилга	35,662	37,140	1,478
Тээврийн хэрэгсэл	1,723	1,605	(118)

- ҮЖ170. БНҮА-ны өмнө нь хянаж байсан үндсэн хөрөнгийн зүйлсийн дансны үнэ нь 20Х5 оны 10 дугаар сарын 01-нээр шинэчлэгдэн баяжигдсан эсэхийг ханган магадлах үүднээс түүний дансны үнийг ҮБ мөн нягталж шалгасан. БНҮА-ны өмнө нь хянаж байсан үндсэн хөрөнгийн зүйлсийн дансны үнэ нь шинэчлэгдэн баяжигдсан бөгөөд тохируулга шаардлагагүй гэдгийг нягтлах шалгалтаар баталгаажуулсан.

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

ҮЖ171. БНҮА-ны өмнө нь хянаж байсан үндсэн хөрөнгийн зүйлсийг ҮБ нь тэдгээрийн дансны үнээр хүлээн зөвшөөрсөн. УСНББОУС 17-гийн 67-р параграфт заасанчлан, ҮБ нь АНҮА ба БНҮА-ны аль алины өмнө нь хянаж байсан үндсэн хөрөнгийн зүйлсийн үлдэх өртөг болон ашиглалтын хугацааг наад зах нь тайлант жил бүрийн эцэст нягталж шалгана. Хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал ҮБ нь уг өөрчлөлтийг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт байдлаар тайлагнана.

### Төлөх ёстой татварыг нийлүүлэлтийн үр дүнд чөлөөлөх

*Нийлүүлэлтээр үүссэн татварын чөлөөлөлтийг УСНББОУС 40-ийн 33-34, МЗУ57-МЗУ58-р параграфыг мөрдсөнөөр тайлагнахын үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ172. Нийлүүлэлтийн нөхцлийн нэг хэсэг байдлаар тухайн үр дүнгийн байгууллагын татварын өр төлбөрийг чөлөөлөх, тийм ерөнхий хяналтанд байдаггүй нийлүүлэлтийн тайлагналыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

ҮЖ173. 20Х6 оны 01 дүгээр сарын 01-нд АНҮА ба БНҮА болох улсын секторын хоёр байгууллагын нийлүүлэлтээр ҮБ-ыг үүсгэн байгуулсан. Үндэсний засгийн газар нь уг нийлүүлэлтийг тулган хэрэгжүүлсэн. ҮБ, АНҮА, БНҮА нь нягтлан бодох бүртгэлийн нэг ижил бодлоготой; Үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд АНҮА болон БНҮА-ны тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд тохируулга хийх шаардлагагүй юм. Уг нийлүүлэх өдрөөр АНҮА болон БНҮА-ын хооронд төлөгдөөгүй үлдэгдэл байхгүй.

ҮЖ174. ҮБ нь АНҮА ба БНҮА-ны хөрөнгө, өр төлбөрийг уг нийлүүлэх өдрөөрх тэдгээрийн тус тусын санхүүгийн тайлан дахь дансны үнээр 20Х6 оны 01 дүгээр сарын 01-нд өөрийн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч, хэмжинэ.

Санхүүгийн байдлын тайлан	АНҮА (ТН)	БНҮА (ТН)	ҮБ (ТН)
Санхүүгийн хөрөнгө	1,205	997	2,202
Бараа материал	25	42	67
Үндсэн хөрөнгө	21,944	18,061	40,005
Тодорхойлогдох биет бус хөрөнгө	0	3,041	3,041
Санхүүгийн өр төлбөр	(22,916)	(22,020)	(44,936)
Татварын өр төлбөр	(76)	(119)	(195)
Цэвэр хөрөнгийн дүн	182	2	184
Цэвэр хөрөнгө/өмч	182	2	184

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

ҮЖ175. Сангийн яам (СЯ) (татварын эрх бүхий байгууллага) нь ҮБ-ыг татварын өр төлбөрөөс чөлөөлөхөөр уг нийлүүлэлтийн нөхцөлд тусгасан гэж үзье. ҮБ нь тухайн татварын өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрч, цэвэр хөрөнгө/өмчид тохируулга хийнэ. ҮБ-ын 20Х6 оны 01 дүгээр сарын 01-нээрх санхүүгийн байдлын тайлан нь дараах байдалтай болно:

Санхүүгийн байдлын тайлан	ҮБ (ТН)
Санхүүгийн хөрөнгө	2,202
Бараа материал	67
Үндсэн хөрөнгө	40,005
Биет бус хөрөнгө	3,041
Санхүүгийн өр төлбөр	(44,936)
Татварын өр төлбөр	0
Цэвэр хөрөнгийн дүн	379
Цэвэр хөрөнгө/өмч	379

ҮЖ176. СЯ нь татварын авлагыг УСНББОУС 23-ын дагуу тайлагнах ба чөлөөлсөн татварын хувьд тохируулгыг хүлээн зөвшөөрнө.

**Нийлүүлэлтийн үр дүнд цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийг хүлээн зөвшөөрч, хэмжих**

*УСНББОУС 40-ийн 37-39 -р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ177. Нийлүүлэлтийн хувьд цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн тайлагналыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

ҮЖ178. Бусад нутгийн засаг захиргааны газар зүйн хоёр бүстэй холбоотойгоор өмнө нь ерөнхий хяналтанд байдаггүй байсан АНҮА ба БНҮА гэсэн үйл ажиллагаануудын нийлүүлэлтээр 20Х4 оны 6 дугаар сарын 01-нд шинэ засаг захиргааны ҮБ-ыг үүсгэн байгуулсан.

ҮЖ179. БНҮА нь АНҮА-д өмнө нь үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үүнд 750ТН-ийг төлнө. Уг нийлүүлэх өдрөөр үүнийг төлөөгүй байсан. Энэхүү ажил гүйлгээ нь АНҮА-ны хувьд санхүүгийн өр төлбөрийн дансны үнийн, харин БНҮА-ны хувьд санхүүгийн хөрөнгийн дансны үнийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

ҮЖ180. АНҮА нь өртгийн загвар ашигласнаар үндсэн хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өмнө нь мөрддөг байсан. БНҮА нь дахин үнэлгээний загвар ашигласнаар үндсэн хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өмнө нь мөрддөг байсан. ҮБ нь дахин үнэлгээний загвар ашигласнаар үндсэн хөрөнгийг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлого баримталсан. ҮБ нь АНҮА-ны өмнө нь хянаж байсан үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд хараат бус үнэлгээ хийлгэсэн. Үүний үр дүнд тэдгээр үндсэн хөрөнгийн зүйлсийн дансны үнийг 5,750 ТН-ээр



УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

нэмэгдүүлсэн бөгөөд цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүнд харгалзах тохируулгыг хийсэн.

ҮЖ181. Шилжүүлсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийн дансны үнийг доор нэгтгэн харуулав. АНҮА ба БНҮА-ны хооронд хийгдсэн ажил гүйлгээг устгах (22-р параграфыг үзнэ үү) болон уг үр дүнгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой дансны үнийг нийцүүлэх тохируулгыг мөн доор харуулав.

	АНҮА (ТН)	БНҮА (ТН)	Устгал- тын тохируу- лах бичилт (ТН)	Нягтлан бодох бүртгэлийн тохируулах бичилт (ТН)	ҮБ-ын эхний үлдэг- дэл (ТН)
Санхүүгийн хөрөнгө	11,248	17,311	(750)		27,809
Бараа материал	1,072	532			1,604
Үндсэн хөрөнгө	5,663	12,171		5,750	23,584
Биет бус хөрөнгө	0	137			137
Санхүүгийн өр төлбөр	(18,798)	(20,553)	750		(38,601)
Цэвэр хөрөнгө/ (өр төлбөр)- ийн дүн	(815)	9,598		5,750	14,533
Дахин үнэлгээний нэмэгдэл	0	6,939		5,750	12,689
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(815)	2,659			1,844
Цэвэр хөрөнгө/өмч	(815)	9,598	0	5,750	14,533

ҮЖ182. УСНББОУС 40-ийн 37-39-р параграфын дагуу ҮБ нь цэвэр хөрөнгө/өмчийг 14,533 ТН-ийн эхлэлийн нэг үлдэгдэл дүн байдлаар эсвэл дээр харуулсанчлан, тусдаа бүрэлдэхүүн хэсэг байдлаар толилуулж болох юм.

ҮЖ183. Энэхүү нийлүүлэлтээс өмнө АНҮА ба БНҮА-г хянаж байсан бусад нутгийн засаг захиргаа нь ҮБ-д шилжүүлсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг бусад УСНББОУС-уудын дагуу үл хүлээн зөвшөөрнө.

## Нийлүүлэлтийн хэмжилтийн хугацаа

*УСНББОУС 40-ийн 40-44 -р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

- ҮЖ184. Нийлүүлэлтийн анхны тайлагнал нь уг нийлүүлэлт хийгдсэн санхүүгийн тайлант үеийн эцэст эцэслэн дуусгаагүй байвал тухайн үр дүнгийн байгууллага нь тайлагнаж хараахан дуусаагүй зүйлсийн хувьд тооцсон нөхцөлт дүнг өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч тусгахыг УСНББОУС 40-ийн 40-р параграф шаардсан байдаг. Нийлүүлэх өдрөөр оршин байсан бөгөөд хэрэв мэдэгдсэн бол уг өдрөөр хүлээн зөвшөөрсөн дүнгийн хэмжилтэнд нөлөөлөх байсан баримт материал болон нөхцөл байдлын талаар олж авсан шинэ мэдээллийг тусгахад шаардлагатай тэрхүү нөхцөлт дүнд хийх тохируулгыг тухайн үр дүнгийн байгууллага нь хэмжилтийн хугацааны туршид хүлээн зөвшөөрнө. Үр дүнгийн байгууллага нь ийм тохируулгыг уг нийлүүлэлтийн өдрөөр тухайн нийлүүлэлтийн тайлагналыг эцэслэн дуусгасан байдлаар хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 40-ийн 43-р параграфтаар шаарддаг. Хэмжилтийн хугацааны тохируулгыг ашиг, алдагдалд тусгахгүй.
- ҮЖ185. АНҮА ба БНҮА (уг нийлүүлэлтээс өмнө ерөнхий хяналтанд байгаагүй хоёр нутгийн засаг захиргаа)-ны нийлүүлэлтээр ҮБ-ыг 20X3 оны 11 дүгээр сарын 30-нд үүсгэн байгуулсан гэж үзье. Нийлүүлэлтээс өмнө АНҮА нь газар, барилгыг хэмжихдээ дахин үнэлгээний загварыг ашиглах нягтлан бодох бүртгэлийн бодлоготой байсан, харин БНҮА нь газар, барилгыг хэмжихдээ өртгийн загварыг ашиглах нягтлан бодох бүртгэлийн бодлоготой байсан. ҮБ нь дахин үнэлгээний загвар ашигласнаар газар, барилгыг хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдсөн бөгөөд БНҮА-ны өмнө хянаж байсан газар, барилгын хувьд хараат бус үнэлгээ хийлгэх гэж байна. ҮБ нь 20X3 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангаа гаргахыг зөвшөөрсөн өдрөөр энэхүү үнэлгээ хараахан эцэслэн дуусаагүй байсан. ҮБ нь газар ба барилгын нөхцөлт дүнг өөрийн 20X3 оны жилийн санхүүгийн тайландаа харгалзан 150,000 ТН болон 275,000 ТН-ээр хүлээн зөвшөөрсөн. Уг нийлүүлэх өдөр барилга нь арван таван жилийн үлдсэн ашиглалтын хугацаатай байсан. Газар нь тодорхойгүй ашиглалтын хугацаатай юм. Нийлүүлэх өдрөөс хойш дөрвөн сарын дараа ҮБ нь хараат бус үнэлгээ хийлгэсэн бөгөөд тэрхүү нийлүүлэх өдрөөр газрын үнэ цэнийг 160,000 ТН, барилгын үнэ цэнийг 365,000 ТН гэж тооцоолсон.
- ҮЖ186. 20X4 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайландаа ҮБ нь 20X3 онд хамаарах өмнөх жилийн мэдээллийг дараах байдлаар буцаах горимоор залруулсан:
- (а) 20X3 оны 12 дугаар сарын 31-нээр газрын дансны үнийг 10,000 ТН-ээр нэмэгдүүлсэн. Газар нь тодорхойгүй ашиглалтын хугацаатай тул элэгдэл тооцохгүй.
  - (б) 20X3 оны 12 дугаар сарын 31-нээр барилгын дансны үнийг 89,500 ТН-ээр нэмэгдүүлсэн. Хэрэв нийлүүлэх өдрөөр хөрөнгийг тухайн

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

үнэ цэнээр хэмжсэн бол тэрхүү өдрөөс хойш хүлээн зөвшөөрөх байсан нэмэлт элэгдлийг (нэг сарын элэгдэл 500 ТН) уг нийлүүлэх өдрөөрх 90,000 ТН-ийн үнэлгээний залруулгаас хасах замаар залруулгын дүнг хэмжсэн.

- (в) 100,000 ТН-ийн залруулгыг 20Х3 оны 12 дугаар сарын 31-нээр цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн.
  - (г) 20Х3 оны элэгдлийн зардлыг 500 ТН-ээр нэмэгдүүлсэн.
- ҮЖ187. УСНББОУС 40-ийн 56-р параграфын дагуу ҮБ нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) 20Х3 оны санхүүгийн тайлангийн хувьд, БНҮА-ны өмнө нь хянаж байсан газар болон барилгын үнэлгээ хараахан дуусаагүй тул нийлүүлэлтийн анхны тайлагнал эцэслээгүй байсан талаар.
  - (б) 20Х4 оны санхүүгийн тайлангийн хувьд, тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнд хийсэн тохируулгын дүн ба тайлбарыг тодруулна. Иймээс ҮБ нь газар ба барилгын үнэ цэнийг 99,500 ТН-ээр нэмэгдүүлэх (нийлүүлэх өдрөөрх 100,000 ТН), элэгдлийн зардлыг 500 ТН-ээр нэмэгдүүлэх, цэвэр хөрөнгө/ өмчийг 100,000 ТН-ээр нэмэгдүүлэхийн тулд 20Х3 оны зэрэгцүүлэгдэх мэдээллийг буцаах горимоор залруулсан гэдгийг тодруулна.

### **Нийлүүлэлтийн үр дүнд өөрчлөгдөж болох шалгуурт үндэслэн тухайн нэгдэгч үйл ажиллагааны хүлээн авсан шилжүүлгийн дараагийн тайлант үеийн хэмжилт**

*УСНББОУС 40-ийн 48, МЗУ61-МЗУ63-р параграфын шаардлагуудыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

- ҮЖ188. Нийлүүлэлтийн үр дүнд өөрчлөгдөж болох шалгуурт үндэслэн тухайн нэгдэгч үйл ажиллагааны хүлээн авсан шилжүүлгийн дараагийн тайлант үеийн тайлагналыг үлгэрчлэн харуулав.
- ҮЖ189. 20Х3 оны 01 дүгээр сарын 01-нд үндэсний засгийн газар нь босго шалгуураас доогуур өрхийн дундаж орлоготой тэдгээр нутгийн захиргаадад жил тутмын буцалтгүй тусламжийг олгосон. 20Х3 оны 6 дугаар сарын 01-нд одоо оршин байгаа АНҮА ба БНҮА гэсэн хоёр нутгийн засаг захиргааны нийлүүлэлтээр шинэ нутгийн захиргааг үүсгэн байгуулсан. АНҮА нь өөрийн өрхийн дундаж орлогод үндэслэн 1,000 ТН-ийн буцалтгүй тусламжийг өмнө нь авсан байсан. БНҮА-ны өрхийн дундаж орлого нь босго шалгуураас өндөр байсан тул буцалтгүй тусламж аваагүй.
- ҮЖ190. 20Х3 оны 6 дугаар сарын 01-ний нийлүүлэлтийн дараа ҮБ-ын өрхийн дундаж орлого нь буцалтгүй тусламж олгох үедээ засгийн газрын тогтоосон босго шалгуураас өндөр байсан.
- ҮЖ191. 20Х3 оны 7 дугаар сарын 01-нд үндэсний засгийн газар нь АНҮА-д өмнө олгосон буцалтгүй тусламжийн нэг хэсэг (200 ТН)-ийг буцаан төлөхийг

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

ҮБ-аас шаардсан. ҮБ нь 20X3 оны 7 дугаар сарын 01-нд 200 ТН-ийн өр төлбөр ба зардлыг хүлээн зөвшөөрсөн.

### Нийлүүлэлттэй холбоотой тодруулгын шаардлагууд

*УСНББОУС 40-ийн 53-57 -р параграф дахь тодруулгын шаардлагуудыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ192. Нийлүүлэлттэй холбоотой УСНББОУС 40-ийн тодруулгын зарим шаардлагуудыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан; эдгээр нь бодит ажил гүйлгээнд үндэслээгүй болно. Энэ жишээнд ҮБ нь АНҮА ба БНҮА гэсэн хуучин хоёр нутгийн захиргааг нийлүүлэх замаар шинээр үүсгэн байгуулсан нутгийн захиргаа гэж үзсэн. Үлгэрчлэн харуулсан тодруулгын тусгай шаардлагуудад харгалзах тодруулгыг энэхүү жишээнд хүснэгтэн хэлбэрээр харуулсан. Бодит хөлийн тэмдэглэл нь энгийн хүүрнэсэн хэлбэрээр үлгэрчлэн харуулж болох олон тодруулгыг илэрхийлж болох юм.

#### Харгалзах параграф

54(а)-(в) 20X2 оны 6 дугаар сарын 30-нд АНҮА ба БНҮА гэсэн хуучин нутгийн захиргаадын нийлүүлэлтээр ҮБ-ыг үүсгэн байгуулсан. Энэхүү нийлүүлэлтээр АНҮА ба БНҮА-ны аль нь ч уг ҮБ-ын хяналтыг олж аваагүй. Нийлүүлэлтийг АНҮА ба БНҮА харилцан хүлээн зөвшөөрсөн бөгөөд хууль тогтоомжийн дагуу Засгийн газар үүнийг хэрэгжүүлсэн. Энэхүү нийлүүлэлт нь цар хүрээний хэмнэлтээр өртөг зардлыг бууруулах ба иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилготой.

54(г) **Шилжүүлсэн хөрөнгө ба өр төлбөрийн гол анги тус бүрийн хувьд 20X2 оны 6 дугаар сарын 30-наар хүлээн зөвшөөрсөн дүнгүүд**

	ТН
Санхүүгийн хөрөнгө	1,701
Бараа материал	5
Үндсэн хөрөнгө	74,656
Биет бус хөрөнгө	42
Санхүүгийн өр төлбөр	(2,001)
Цэвэр хөрөнгийн дүн	74,403

54(д) Нийлүүлэлтээс өмнө, 20X2 оны 6 дугаар сарын 30-наар АНҮА ба БНҮА-ны бүртгэсэн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд дараах тохируулгыг хийсэн:

	Анхны дүн (ТН)	Тохируулга (ТН)	Тохируулсан дүн (ТН)
54(д)(i) БНҮА-тай хийсэн ажил гүйлгээг устгаж цэвэрлэхийн тулд АНҮА-ны бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн дахин илэрхийлэлт	822	(25)	797

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

54(д)(i)	АНҮА-тай хийсэн ажил гүйлгээг устгаж цэвэрлэхийн тулд БНҮА-ны бүртгэсэн (1,093) санхүүгийн өр төлбөрийн дахин илэрхийлэлт	25	(1,068)
54(д)(ii)	Үндсэн хөрөнгийн зүйлсийг дахин үнэлгээний загвар ашиглан хэмжихийн 12,116 тулд АНҮА-ны бүртгэсэн үндсэн хөрөнгийг дахин илэрхийлэх	17,954	30,070

54(e) **20X2 оны 6 дугаар сарын 30-наар Цэвэр хөрөнгө/өмчид  
хүлээн зөвшөөрсөн дүн**

	АНҮА (ТН)	БНҮА (ТН)	Тохируулга (ТН)	ҮБ (ТН)
Дахин үнэлгээний нэмэгдэл	0	18,332	17,954	36,286
Хуримтлагдсан ашиг, алдагдал	12,047	26,070	0	38,117
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>12,047</u>	<u>44,402</u>	<u>17,954</u>	<u>74,403</u>

54(и) Эдгээр санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн үед АНҮА ба БНҮА-ны тайлагналын хамгийн сүүлийн өдөр нь 20X1 оны 12 дугаар сарын 31 байсан. 20X2 оны 01 дүгээр сарын 01-нээс нийлүүлэлтийн өдөр (20X2 оны 6 дугаар сарын 30) хүртэлх хугацаанд гарсан АНҮА ба БНҮА-ны орлого, зардал, ашиг алдагдал, түүнчлэн хөрөнгө, өр төлбөрийн гол анги тус бүрийн болон цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд АНҮА ба БНҮА-ны тайлагнасан дүнгүүдийг доор харуулав:

	АНҮА (ТН)	БНҮА (ТН)
54(и)(i) <b>Орлого</b>		
Үл хөдлөх хөрөнгийн татвар	45,213	70,369
Арилжааны ажил гүйлгээний орлого	2,681	25,377
Засгийн газрын бусад байгууллагуудаас авсан шилжүүлэг	32,615	19,345
<b>Орлогын дүн</b>	<u>80,509</u>	<u>115,091</u>
54(и)(i) <b>Зардал</b>		
Цалин, хөлс, ажилтны тэтгэмж	(51,263)	(68,549)
Буцалтгүй тусламж ба бусад шилжүүлгийн төлбөр	(18,611)	(26,445)
Ашигласан хангамжийн ба хэрэглээний зүйлс	(7,545)	(13,391)
Элэгдлийн зардал	(677)	(2,598)
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	(17)	(33)
Санхүүгийн зардал	(2)	(3)
<b>Зардлын дүн</b>	<u>(78,115)</u>	<u>(111,019)</u>

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

54(и)(i)	<b>20X2 оны 01 дүгээр сарын 01-нээс 20X2 оны 6 дугаар сарын 30 хүртэлх тайлант үеийн ашиг (алдагдал)</b>	2,394	4,072
54(и)(ii)	<b>20X2 оны 6 дугаар сарын 30-наарх хөрөнгө</b>		
	Санхүүгийн хөрөнгө	822	904
	Бараа материал	0	5
	Үндсэн хөрөнгө	12,116	44,586
	Биет бус хөрөнгө	42	0
	<b>Хөрөнгийн дүн</b>	<b>12,980</b>	<b>45,495</b>
54(и)(ii)	<b>20X2 оны 6 дугаар сарын 30-наарх өр төлбөр</b>		
	Санхүүгийн өр төлбөр	(933)	(1,093)
	<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>(933)</b>	<b>(1,093)</b>
54(и)(iii)	<b>20X2 оны 6 дугаар сарын 30-наарх цэвэр хөрөнгө</b>	12,047	44,402
	<b>20X2 оны 6 дугаар сарын 30-наарх цэвэр хөрөнгө</b>		
	Дахин үнэлгээний нэмэгдэл	0	18,332
	Хуримтлагдсан ашиг, алдагдал	12,047	26,070
	<b>20X2 оны 6 дугаар сарын 30-наарх цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>12,047</b>	<b>44,402</b>

Нийлүүлэлттэй холбоотой тодруулгыг авч үзэх үедээ, байгууллага нь УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга* дахь материаллаг байдлын талаархи хэлэлцүүлгийг харгалзан үзэх нь ач холбогдолтой байж болох юм.

### Худалдан авалтын тайлагнал

#### Сөрөг худалдан авалт

*УСНББОУС 40-ийн МЗУ66-МЗУ71-р параграфыг дагаж мөрдсөнөөр сөрөг худалдан авалтыг хүлээн зөвшөөрсний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ193. Хууль ёсны хяналтанд буй байгууллага болох Б байгууллага нь өмчийн хэрэглүүр гаргаж байгаа А байгууллагыг, өөрөөр хэлбэл хууль ёсны хяналт тавигч байгууллагыг сөрөг худалдан авалтаар 20X6 оны 9 дүгээр сарын 30-нд худалдан авсан сөрөг худалдан авалтын тайлагналыг энэхүү жишээнд үлгэрчлэн харуулсан. Энэ жишээнд орлогын татварын аливаа үр нөлөөг харгалзан үзээгүй болно.

ҮЖ194. Худалдан авалтын яг өмнөх А байгууллага ба Б байгууллагын санхүүгийн байдлын тайлан нь дараах байдалтай байсан:

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

	А байгууллага (хууль ёсны хяналт тавигч байгууллага, нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагаа) ТН	Б байгууллага (хууль ёсны хяналтанд буй байгууллага, нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгч) ТН
Эргэлтийн хөрөнгө	500	700
Эргэлтийн бус хөрөнгө	1,300	3,000
Нийт хөрөнгө	<u>1,800</u>	<u>3,700</u>
Богино хугацаат өр төлбөр	300	600
Урт хугацаат өр төлбөр	400	1,100
Өр төлбөрийн дүн	<u>700</u>	<u>1,700</u>
Хувьцаа эзэмшигчдийн өмч		
Хуримтлагдсан ашиг, алдагдал	800	1,400
Гаргасан өмч:		
100 ширхэг энгийн хувьцаа	300	
60 ширхэг энгийн хувьцаа		600
Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүн	<u>1,100</u>	<u>2,000</u>
Нийт өр төлбөр ба өмч	<u>1,800</u>	<u>3,700</u>

ҮЖ195. Энэ жишээнд мөн дараах мэдээллийг ашигласан:

- (а) 20Х6 оны 9 дүгээр сарын 30-нд А байгууллага нь Б байгууллагын нэг энгийн хувьцаа бүрийн хариуд 2.5 ширхэг хувьцаа гаргасан. Б байгууллагын цорын ганц хувь эзэмшигч болох засгийн газар нь Б байгууллага дахь өөрийн хувьцааг арилжсан. Иймээс А байгууллага нь Б байгууллагын бүх 60 ширхэг энгийн хувьцааны хариуд 150 ширхэг энгийн хувьцаа гаргасан.
- (б) 20Х6 оны 9 дүгээр сарын 30-нд Б байгууллагын нэгж энгийн хувьцааны бодит үнэ цэнэ нь 40 ТН байсан. А байгууллагын энгийн хувьцааны зах зээлийн жишиг үнэ нь уг өдөр 16 ТН байв.
- (в) 20Х6 оны 9 дүгээр сарын 30-нд А байгууллагын эргэлтийн бус хөрөнгийн бодит үнэ цэнэ 1,500 ТН байсан, үүнээс бусад, уг А байгууллагын 20Х6 оны 9 дүгээр сарын 30-наарх тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнэтэй тэнцүү байсан.

*Шилжүүлсэн төлбөрийн бодит үнэ цэнийг тооцоолох*

ҮЖ196. А байгууллага (хууль ёсны хяналт тавигч байгууллага, нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагаа) 150 ширхэг энгийн хувьцаа гаргасны үр дүнд Б байгууллагын хувьцаа эзэмшигч (засгийн газар) нь уг нэгдсэн байгууллагын гаргасан хувьцааны 60 хувийг (өөрөөр хэлбэл, гаргасан 250 ширхэг хувьцааны 150 ширхэг хувьцааг) эзэмшсэн. Үлдсэн 40 хувийг А байгууллагын хувьцаа эзэмшигчид өмчилдөг. Хэрэв Б байгууллага нь А байгууллага дахь энгийн хувьцааны хариуд А байгууллагын хувьцаа эзэмшигчдэд өөрийн нэмэлт энгийн хувьцааг гаргах хэлбэрээр худалдан авалтыг хийсэн байсан бол Б байгууллага нь уг нэгдсэн байгууллага дахь өмчлөлийн хувь оролцооны харьцааг хэвээр хадгалахын тулд 40 ширхэг хувьцаа гаргах ёстой байсан. Ингэснээр Б байгууллагын хувьцаа эзэмшигч (засгийн газар) нь Б байгууллагын гаргасан 100 ширхэг хувьцаанаас 60 ширхэгийг буюу уг нэгтгэсэн байгууллагын 60 хувийг эзэмших байсан. Үүний үр дүнд Б байгууллагын зохих ёсоор шилжүүлсэн төлбөрийн бодит үнэ цэнэ ба А байгууллага дахь тухайн бүлгийн хувь оролцоо нь 1,600 ТН (нэгжийн 40 ТН-ийн бодит үнэ цэнэ бүхий 40 ширхэг хувьцаа) болно.

ҮЖ197. Зохих ёсоор шилжүүлсэн төлбөрийн бодит үнэ цэнэ нь хамгийн найдвартай хэмжилтэнд үндэслэвэл зохино. Энэ жишээнд А байгууллагын хувьцааны үндсэн (буюу хамгийн их давуу талтай) зах зээлийн жишиг үнэ нь зохих ёсоор шилжүүлсэн төлбөрийг хэмжихэд Б байгууллагын хувьцааны бодит үнэ цэнээс илүү найдвартай сууриар хангадаг бөгөөд А байгууллагын хувьцааны, өөрөөр хэлбэл нэгжийн 16 ТН-ийн бодит үнэ цэнэтэй 100 ширхэг хувьцааны зах зээлийн үнийг ашигласнаар уг төлбөрийг хэмжинэ.

*Гүүдвилийг хэмжих*

ҮЖ198. А байгууллагын хүлээн зөвшөөрсөн, тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн цэвэр дүнгээс уг зохих ёсоор шилжүүлсэн төлбөрийн (А байгууллага дахь тухайн бүлгийн хувь оролцооны) бодит үнийн давж илүү гарсан дүнгээр гүүдвилийг хэмждэг.

	ТН	ТН
Зохих ёсоор шилжүүлсэн төлбөр		1,600
А байгууллагын тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрсөн цэвэр дүн		
Эргэлтийн хөрөнгө	500	
Эргэлтийн бус хөрөнгө	1,500	
Богино хугацаат өр төлбөр	(300)	
Урт хугацаат өр төлбөр	(400)	(1,300)
Гүүдвил		<u>300</u>



УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

20Х6 оны 9 дүгээр сарын 30-ны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

ҮЖ199. Энэхүү худалдан авалтын яг дараах, нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан нь дараах байдалтай байна:

	<b>ТН</b>
Эргэлтийн хөрөнгө [700 ТН + 500 ТН]	1,200
Эргэлтийн бус хөрөнгө [3,000 ТН + 1,500 ТН]	4,500
Гүүдвил	300
Хөрөнгийн дүн	<u>6,000</u>
Богино хугацаат өр төлбөр [600 ТН + 300 ТН]	900
Урт хугацаат өр төлбөр [1,100 ТН + 400 ТН]	1,500
Өр төлбөрийн дүн	<u>2,400</u>
Хувьцаа эзэмшигчдийн өмч	
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,400
Гаргасан өмч:	
250 энгийн хувьцаа [600 ТН + 1,600 ТН]	2,200
Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүн	<u>3,600</u>
Нийт өр төлбөр ба өмч	<u>6,000</u>

ҮЖ200. Худалдан авалтын яг өмнөх уг хууль ёсны хяналтанд буй байгууллагын гаргасан өмч (600 ТН) дээр тэрхүү зохих ёсоор шилжүүлсэн төлбөрийн бодит үнэ цэнийг (1,600 ТН) нэмсэнээр тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан өмчийн хувь оролцоо байдлаар хүлээн зөвшөөрсөн дүнг (2,200 ТН) тодорхойлно. Гэвч нэгтгэсэн санхүүгийн тайланд харуулах өмчийн бүтэц (өөрөөр хэлбэл, гаргасан өмчийн хувь оролцооны тоо ба төрөл) нь уг хууль ёсны хяналт тавигч байгууллагын өмчийн бүтцийг, үүн дотроо тэрхүү нэгдлийг хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны хяналт тавигч байгууллагын гаргасан өмчийн хувь оролцоог тусгах ёстой.

*Хяналтын бус хувь оролцоо*

ҮЖ201. Б байгууллага нь нэгээс олон хувьцаа эзэмшигчтэй бөгөөд Б байгууллагын 60 ширхэг энгийн хувьцааны ердөө 56 ширхэгийг арилжсан гэдгээс бусад өгөгдөл нь дээр дурдсантай ижил гэж үзье. А байгууллага нь Б байгууллагын нэг энгийн хувьцаа бүрийн хариуд 2.5 ширхэг хувьцаа гаргасан учраас А байгууллага нь ердөө 140 (150 биш) ширхэг хувьцаа гаргасан. Үүний үр дүнд Б байгууллагын хувьцаа эзэмшигчид нь уг нэгдсэн байгууллагын гаргасан хувьцааны 58.3 хувь (гаргасан 240 ширхэг хувьцаанаас 140 ширхэг)-ийг өмчилнө. Б байгууллага нь А байгууллага дахь энгийн хувьцааны хариуд А байгууллагын хувьцаа эзэмшигчдэд өөрийн нэмэлт энгийн хувьцааг гаргаснаар уг нэгдлийг хийсэн гэж үзээд уг нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагаа болох А байгууллагад шилжүүлсэн төлбөрийн бодит үнэ цэнийг тооцоолно. Яагаад гэвэл, Б байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгч бөгөөд нэгтгэгч нь нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагааны

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

хувьд арилжсан төлбөрийг хэмжихийг УСНББОУС 40-ийн МЗУ67-р параграфтаар шаардсан байдаг.

- ҮЖ202. Б байгууллагын гаргах ёстой хувьцааны тоог тооцоолохдоо хяналтын бус хувь оролцоог уг тооцоолдолд харгалзан оруулдаггүй. Олонхийн хувьцаа эзэмшигч (засгийн газар) нь Б байгууллагын 56 ширхэг хувьцааг өмчилдөг. Өмчийн хувь оролцооны 58.3 хувийг илэрхийлэхийн тулд Б байгууллага нь нэмэлт 40 ширхэг хувьцааг гаргах шаардлагатай болно. Ингэснээр олонхийн хувьцаа эзэмшигч (засгийн газар) нь Б байгууллагын гаргасан 96 ширхэг хувьцааны 56 ширхэгийг, иймээс тухайн нэгдсэн байгууллагын 58.3 хувийг эзэмшинэ. Үүний үр дүнд нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагаа болох А байгууллагад шилжүүлсэн төлбөрийн бодит үнэ цэнэ нь 1,600 ТН (өөрөөр хэлбэл, нэгжийн 40 ТН-ийн бодит үнэ цэнэ бүхий 40 ширхэг хувьцаа) болно. Энэ нь Б байгууллагын цор ганц хувьцаа эзэмшигчийн зүгээс 60 ширхэг энгийн хувьцааг бүгдийг авахын тулд санал болгож буй дүнтэй тэнцүү байна. Б байгууллагын зарим хувьцаа эзэмшигчид нь энэхүү арилжаанд оролцоогүй тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн худалдан авсан үйл ажиллагаа болох А байгууллага дахь тухайн бүлгийн хувь оролцооны хувьд хүлээн зөвшөөрсөн дүн өөрчлөгдөхгүй.
- ҮЖ203. Б байгууллагын нийт 60 ширхэг хувьцаанаас А байгууллагын хувьцаагаар арилжаагүй дөрвөн ширхэг хувьцаа нь хяналтын бус хувь оролцоог илэрхийлнэ. Иймээс хяналтын бус хувь оролцоо нь 6.7 хувь байна. Хяналтын бус хувь оролцоо нь хууль ёсны хяналтанд буй байгууллага болох Б байгууллагын цэвэр хөрөнгийн тухайн нэгдлийн өмнөх дансны үнэ дэх тэдгээр хяналтын бус хувьцаа эзэмшигчдийн хувь тэнцүүлсэн хувь оролцоог илэрхийлнэ. Иймээс Б байгууллагын цэвэр хөрөнгийн уг нэгдлийн өмнөх дансны үнийн 6.7 хувийн (өөрөөр хэлбэл, 2,000 ТН-ийн 6.7 хувь буюу 134ТН) хяналтын бус хувь оролцоог харуулахын тулд нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд тохируулга хийнэ.
- ҮЖ204. Хяналтын бус хувь оролцоог тусгасан, 20Х6 оны 9 дүгээр сарын 30-ны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан нь дараах байдалтай байна:

	<b>ТН</b>
Эргэлтийн хөрөнгө [700 ТН + 500 ТН]	1,200
Эргэлтийн бус хөрөнгө [3,000 ТН + 1,500 ТН]	4,500
Гүүдвил	300
Хөрөнгийн дүн	<u>6,000</u>
Богино хугацаат өр төлбөр [600 ТН + 300 ТН]	900
Урт хугацаат өр төлбөр [1,100 ТН + 400 ТН]	1,500
Өр төлбөрийн дүн	<u>2,400</u>
Хувьцаа эзэмшигчдийн өмч	
Хуримтлагдсан ашиг, алдагдал [1,400ТН x 93.3 хувь]	1,306
Гаргасан өмч:	
250 энгийн хувьцаа [560 ТН + 1,600 ТН]	2,160

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

Хяналтын бус хувь оролцоо	134
Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүн	3,600
Нийт өр төлбөр ба өмч	6,000

ҮЖ205. 134 ТН-ийн хяналтын бус хувь оролцоо нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Эхний бүрэлдэхүүн хэсэг нь худалдан авалтын яг өмнө уг нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн хуримтлагдсан ашиг дахь хяналтын бус хувь оролцооны дахин ангилсан хэсэг (1,400 ТН х 6.7 хувь буюу 93.80 ТН) юм. Хоёр дахь бүрэлдэхүүн хэсэг нь нягтлан бодох бүртгэлийн нэгтгэгчийн гаргасан өмч дэх уг хяналтын бус хувь оролцооны дахин ангилсан хэсэг (600ТН х 6.7 хувь буюу 40.20ТН) юм.

**Худалдан авалтын тодорхойлогдох биет бус хөрөнгө**

*УСНББОУС 40-ийн 64-68, МЗУ75-МЗУ84-р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ206. Худалдан авалтаар олж эзэмшсэн тодорхойлогдох биет бус хөрөнгүүдийн жишээг доор харуулав. Зарим жишээ нь биет бус хөрөнгөөс өөр бусад хөрөнгийн шинж чанартай байж болох юм. Нэгтгэгч нь ийм хөрөнгийг тэдгээрийн шинж чанарын дагуу тайлагнана. Эдгээр жишээнд бүх зүйлсийг хамруулах зорилгогүй болно.

ҮЖ207. “Заавал биелүүлэх хэлцэл”-д суурилсан гэж тодорхойлсон биет бус хөрөнгүүд нь заавал биелүүлэх хэлцлээс үүссэн биет бус хөрөнгүүд (үүн дотроо, гэрээний эрх буюу бусад хуулийн эрх) юм. “Заавал биелүүлэх хэлцэл”-д суурилагагүй гэж тодорхойлсон биет бус хөрөнгүүд нь нь заавал биелүүлэх хэлцлээс үүсээгүй боловч салган тусгаарлаж болох хөрөнгүүд юм. Заавал биелүүлэх хэлцэлд суурилсан гэж тодорхойлсон биет бус хөрөнгүүдийг мөн салган тусгаарлах боломжтой боловч салган тусгаарлах боломжтой байдал нь тухайн хөрөнгө заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангах зайлшгүй шаардлагатай нөхцөл биш юм.

*Маркетингтай холбоотой биет бус хөрөнгө*

ҮЖ208. Маркетингтай холбоотой биет бус хөрөнгийг бараа, үйлчилгээний маркетинг буюу урамшуулалд юуны өмнө ашигладаг. Маркетингтай холбоотой биет бус хөрөнгийн жишээнд дараах зүйлс хамаарна:

<b>Анги</b>	<b>Суурь</b>
Худалдааны тэмдэг, худалдааны нэр, үйлчилгээний тэмдэг, хамтын худалдааны тэмдэг, гэрчилгээний тэмдэг	Заавал биелүүлэх хэлцэл
Бүтээгдэхүүний онцлог загвар (өвөрмөц өнгө, хэлбэр дүрс буюу сав баглаа загвар)	Заавал биелүүлэх хэлцэл
Сонины эхний нүүрэнд тавигдах эрх	Заавал биелүүлэх хэлцэл
Интернетийн домэйн нэр	Заавал биелүүлэх хэлцэл
Үл өрсөлдөх хэлцэл	Заавал биелүүлэх хэлцэл

Худалдааны тэмдэг, худалдааны нэр, үйлчилгээний тэмдэг, хамтын худалдааны тэмдэг, гэрчилгээний тэмдэг

ҮЖ209. Худалдааны тэмдэг нь аливаа барааны эх үүсвэрийг заах ба бусдын бараа бүтээгдэхүүнээс ялгахын тулд худалдаанд ашигладаг үг, нэр, тэмдэгт болон бусад хэрэгсэл юм. Үйлчилгээний тэмдэг нь бараа бүтээгдэхүүн биш, харин үйлчилгээний эх үүсвэрийг ялган тодорхойлж өгдөг. Хамтын худалдааны тэмдэг нь бүлгийн гишүүдийн бараа, үйлчилгээг тодорхойлдог. Гэрчилгээний тэмдэг нь бараа, үйлчилгээний газар зүйн гарал үүсэл болон бусад шинж чанарыг баталгаажуулж болох юм.

ҮЖ210. Худалдааны тэмдэг, худалдааны нэр, үйлчилгээний тэмдэг, хамтын худалдааны тэмдэг, гэрчилгээний тэмдэг зэргийг төрийн байгууллагад бүртгүүлэх, худалдаанд тасралтгүй ашиглах болон бусад арга замаар хууль ёсоор хамгаалж болох юм. Хэрэв бүртгүүлэх буюу бусад арга замаар түүнийг хууль ёсоор хамгаалсан бол худалдан авалтаар олж эзэмшсэн худалдааны тэмдэг болон бусад тэмдэг нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангасан биет бус хөрөнгө болно. Бусад нөхцөлд худалдан авалтаар олж эзэмшсэн худалдааны тэмдэг болон бусад тэмдэг нь салган тусгаарлах шалгуурыг хангаж байвал, ихэвчлэн ийм шинжтэй байдаг бөгөөд энэ тохиолдолд гүүдвилээс тусад нь хүлээн зөвшөөрч болно.

ҮЖ211. Худалдааны тэмдэг ба бусад тэмдэгтэй ямагт адил утгатайгаар ашигладаг *брэнд* болон *брэндийн тэмдэг* гэсэн нэр томъёо нь худалдааны тэмдэг (эсвэл үйлчилгээний тэмдэг) болон түүнтэй холбоотой худалдааны нэр, томъёо, жор, технологийн мэдлэг гэх мэт харилцан бие биенийгээ нөхөх хөрөнгүүдийн бүлгийг ихэвчлэн илэрхийлэх маркетингийн ерөнхий нэр томъёо юм. Тухайн бүлгийг бүрдүүлж буй хөрөнгүүд нь ижил төсөөтэй ашиглалтын хугацаатай бол брэнд гэж ерөнхийдөө нэрлэдэг, харилцан бие биенийгээ нөхөх биет бус хөрөнгүүдийн бүлгийг байгууллага нь гүүдвилээс тусад нь нэг хөрөнгө байдлаар хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 40-өөр хориглоогүй байдаг.

Интернетийн домэйн нэр

ҮЖ212. Интернетийн домэйн нэр нь тухайн тодорхой интернэтийн тоон хаягийг тодорхойлоход ашигладаг цорын ганц үсгэн тэмдэгтэн нэр юм. Домэйн нэрийн бүртгэл нь тухайн нэр ба сонгосон компьютерийн хооронд уг бүртгэлийн хугацаанд харидцан холбоо үүсгэдэг. Ийм бүртгэлийг шинэчлэн өөрчлөх боломжтой байдаг. Худалдан авалтаар олж эзэмшсэн тухайн бүртгэлтэй домэйн нэр нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангадаг.

*Үйлчилгээний хэрэглэгч буюу Худалдан авагчтай холбоотой биет бус хөрөнгө*

ҮЖ213. Үйлчилгээний хэрэглэгч буюу Худалдан авагчтай холбоотой биет бус хөрөнгийн жишээнд дараах зүйлс хамаарна:

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

<b>Анги</b>	<b>Суурь</b>
Үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалт	Заавал биелүүлэх хэлцэл байхгүй
Захиалга буюу үйлдвэрлэлийн нөөц захиалга	Заавал биелүүлэх хэлцэл
Худалдан авагчийн заавал биелүүлэх хэлцэл ба тухайн худалдан авагчийн холбогдох харилцаа	Заавал биелүүлэх хэлцэл
Заавал биелүүлэх хэлцлээс бусад арга хэрэгслээр дамжуулан үүссэн худалдан авагчийн харилцаа	Заавал биелүүлэх хэлцэл байхгүй

Үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалт

ҮЖ214. Үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалт нь тэдний нэр, холбоо барих хаяг гэх мэт гээр үйлчилгээний хэрэглэгчдийн талаархи мэдээллээс бүрддэг. Түүнчлэн, үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалт нь тэдний хэрэглээний түүх, хүн ам зүйн мэдээлэл гэх мэт тухайн хэрэглэгчдийн талаархи бусад мэдээллийг агуулсан мэдээллийн сан хэлбэртэй байж болно. Үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалт нь заавал биелүүлэх хэлцлээс (үүн дотроо, гэрээний болон бусад хууль ёсны эрхээс) ихэвчлэн үүсдэггүй. Гэвч үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалтыг ихэвчлэн түрээслэх буюу худалдаж арилждаг. Иймээс худалдан авалтаар олж эзэмшсэн үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалт нь салган тусгаарлах шалгуурыг үндсэндээ хангадаг.

Захиалга буюу үйлдвэрлэлийн нөөц захиалга

ҮЖ215. Захиалга буюу үйлдвэрлэлийн нөөц захиалга нь худалдан авалтын буюу борлуулалтын захиалга гэх мэт заавал биелүүлэх хэлцлээс үүсдэг. Хэдийгээр худалдан авалтын буюу борлуулалтын захиалгыг цуцалж болох боловч худалдан авалтаар олж эзэмшсэн захиалга буюу борлуулалтын нөөц захиалга нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангадаг.

Худалдан авагчийн заавал биелүүлэх хэлцэл ба холбогдох худалдан авагчийн харилцаа

ҮЖ216. Хэрэв байгууллага нь заавал биелүүлэх хэлцлээр дамжуулан худалдан авагчтай харилцаа тогтоосон бол тэдгээр худалдан авагчдын харилцаа нь тухайн заавал биелүүлэх хэлцлийн эрхээс үүсдэг. Иймээс хэдийгээр заавал биелүүлэх хэлцлийн нууц хадгалалт болон бусад нөхцлөөр тэрхүү заавал биелүүлэх хэлцлийг тухайн худалдан авсан үйл ажиллагаанаас бусад нь борлуулах буюу шилжүүлэхийг хориглодог байлаа ч гэсэн худалдан авалтаар олж эзэмшсэн тухайн худалдан авагчийн заавал биелүүлэх хэлцэл болон холбогдох худалдан авагчийн харилцаа нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана.

- ҮЖ217. Худалдан авагчийн заавал биелүүлэх хэлцэл болон холбогдох худалдан авагчийн харилцаа нь хоёр тусдаа биет бус хөрөнгийг илэрхийлж болох юм. Эдгээр хоёр хөрөнгийн ашиглалтын хугацаа болон тэдгээрийн эдийн засгийн үр өгөөжийг ашиглан зарцуулах хэв маяг нь өөр байж болно.
- ҮЖ218. Дараах тохиолдолд байгууллага ба түүний худалдан авагчийн хооронд худалдан авагчийн харилцаа оршин байдаг: (а) байгууллага нь худалдан авагчийн талаар мэдээлэлтэй бөгөөд уг худалдан авагчтай тогтмол харилцаа холбоотой байдаг, (б) худалдан авагч нь тухайн байгууллагатай шууд холбоо тогтоох чадвар боломжтой байдаг. Тухайн худалдан авалтын өдрөөр заавал биелүүлэх хэлцэл оршин байгаа эсэхээс үл хамааран байгууллага нь өөрийн худалдан авагчтай заавал биелүүлэх хэлцэл үүсгэх практиктай бол худалдан авагчийн харилцаа нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана. Борлуулалт буюу үйлчилгээний төлөөлөгчдөөр дамжуулан тогтмол харилцах гэх мэтээр заавал биелүүлэх хэлцлээс өөр бусад арга хэрэгслээр худалдан авагчийн харилцаа бас үүсэж болох юм.
- ҮЖ219. ҮЖ215-р параграфт дурдсанчлан, захиалга буюу үйлдвэрлэлийн нөөц захиалга нь худалдан авалтын буюу борлуулалтын захиалга гэх мэт заавал биелүүлэх хэлцлээс үүсдэг бөгөөд иймээс заавал биелүүлэх хэлцлийн эрх гэж үздэг. Иймээс хэрэв байгууллага нь энэ төрлийн заавал биелүүлэх хэлцлээр дамжуулан өөрийн худалдан авагчтай харилцаа тогтоосон бол уг худалдан авагчийн харилцаа нь заавал биелүүлэх хэлцлийн эрхээс бас үүсэх бөгөөд ингэснээр заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангадаг.

#### Жишээ

- ҮЖ220. Худалдан авалтаар олж эзэмшсэн худалдан авагчийн заавал биелүүлэх хэлцэл болон худалдан авагчийн харилцаа гэсэн биет бус хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.
- (а) Нэгтгэгч байгууллага (НБ) нь 20Х5 оны 12 дугаар сарын 31-нд зорилтот байгууллага (ЗБ)-ыг худалдан авалтаар олж эзэмшсэн. ЗБ нь худалдан авагчид бараа нийлүүлэх таван жилийн хугацааны гэрээтэй. Худалдан авагч нь одоогийн заавал биелүүлэх хэлцлийн хугацааны эцэст гэрээг дахин шинэчлэн үргэлжлүүлнэ гэж НБ ба ЗБ-ын аль аль нь итгэж байгаа. Уг гэрээг салган тусгаарлах боломжгүй.
- Цуцлах боломжтой, үгүй эсэхээс үл хамааран энэхүү гэрээ нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана. Түүнчлэн, ЗБ нь Худалдан авагчтай өөрийн харилцааг заавал биелүүлэх хэлцлээр дамжуулан тогтоодог учраас зөвхөн энэхүү хэлцэл төдийгүй ЗБ-ын Худалдан авагчтай тогтоосон худалдан авагчийн харилцаа нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана.
- (б) НБ нь 20Х5 оны 12 дугаар сарын 31-нд ЗБ-ыг худалдан авалтаар олж эзэмшсэн. ЗБ нь спортын бараа ба цахилгаа хэрэгсэл гэсэн

бизнесийн эрс өөр хоёр чиглэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Худалдан авагч нь ЗБ-аас спортын бараа ба цахилгаан хэрэгслийн аль алиныг худалдан авдаг. ЗБ нь спортын барааны цорын ганц нийлүүлэгч байх заавал биелүүлэх хэлцлийг Худалдан авагчтай байгуулсан боловч уг Худалдан авагчид цахилгаан хэрэгсэл нийлүүлэх ийм заавал биелүүлэх хэлцэл хийгээгүй. ЗБ ба Худалдан авагчийн хооронд зөвхөн нэг ерөнхий худалдан авагчийн харилцаа оршин байна гэж НБ ба ЗБ-ын аль аль нь найдаж байна.

Цуцлах боломжтой, үгүй эсэхээс үл хамааран Худалдан авагчийн спортын барааны цорын ганц нийлүүлэгч байх заавал биелүүлэх хэлцэл нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана. Түүнчлэн, ЗБ нь Худалдан авагчтай өөрийн харилцааг заавал биелүүлэх хэлцлээр дамжуулан тогтоодог учраас уг Худалдан авагчтай тогтоосон харилцаа нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана. ЗБ нь Худалдан авагчтай зөвхөн нэг худалдан авагчийн харилцаатай учраас тухайн харилцааны бодит үнэ цэнэ нь спортын бараа ба цахилгаан хэрэгслийн аль алинтай холбоотойгоор уг Худалдан авагчтай ЗБ-ын тогтоосон харилцааны талаархи таамаглалуудыг тусган агуулсан байдаг. Гэвч НБ нь спортын бараа ба цахилгаан хэрэгслийн хувьд Худалдан авагчтай тогтоосон уг харилцааг өөр хооронд нь салган тусгаарлах боломжтой гэж тодорхойлсон бол цахилгаан хэрэгслийн хувьд Худалдан авагчтай тогтоосон харилцаа нь биет бус хөрөнгө гэж үзэх тодорхойлох зорилгын хувьд салган тусгаарлах шалгуурыг хангах эсэхийг НБ нь үнэлнэ.

- (в) НБ нь 20X5 оны 12 дугаар сарын 31-нд ЗБ-ыг худалдан авалтаар олж эзэмшсэн. ЗБ нь зөвхөн худалдан авалтын болон борлуулалтын захиалгаар дамжуулан өөрийн худалдан авагчидтай бизнес хийдэг. 20X5 оны 12 дугаар сарын 31-нд ЗБ нь өөрийн худалдан авагчдын 60 хувиас хүлээн авсан худалдан авалтын нөөц захиалгатай бөгөөд тэдгээр худалдан авагчид нь бүгд байнгын худалдан авагч нар юм. ЗБ-ын худалдан авагчдын үлдсэн 40 хувь нь мөн байнгын худалдан авагчид юм. Гэвч 20X5 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ЗБ нь эдгээр худалдан авагчидтай худалдан авалтын нээлттэй захиалга буюу бусад заавал биелүүлэх хэлцэлгүй байна.

ЗБ-ын худалдан авагчдын 60 хувиас хүлээн авсан худалдан авалтын захиалга нь тэдгээрийг цуцлах боломжтой, үгүй эсэхээс үл хамааран заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана. Түүнчлэн, ЗБ нь заавал биелүүлэх хэлцлээр дамжуулан өөрийн Худалдан авагчдын 60 хувьтай харилцаа тогтоосон учраас зөвхөн уг худалдан авалтын захиалга төдийгүй ЗБ-ын худалдан авагчийн харилцаа нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана. ЗБ нь өөрийн худалдан авагчдын үлдсэн 40 хувьтай заавал биелүүлэх хэлцэл хийх практиктай учраас тэдгээр худалдан авагчидтай түүний тогтоосон харилцаа нь мөн заавал биелүүлэх хэлцлийн эрхээс бас үүсэх бөгөөд иймээс хэдийгээр ЗБ нь 20X5 оны 12

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

дугаар сарын 31-нээр тэдгээр худалдан авагчидтай заавал биелүүлэх хэлцэл байгуулаагүй боловч энэ нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана.

- (г) НБ нь 20X5 оны 12 дугаар сарын 31-нд даатгалын байгууллага болох ЗБ-ыг худалдан авалтаар олж эзэмшсэн. ЗБ нь тээврийн хэрэгслийн нэг жилийн хугацаатай даатгалын гэрээнүүдийн багцтай бөгөөд даатгалын гэрээ эзэмшигчийн зүгээс тэдгээр гэрээг цуцлах боломжтой юм.

ЗБ нь даатгалын гэрээ эзэмшигч нартай өөрийн харилцааг даатгалын гэрээгээр дамжуулан тогтоосон тул даатгалын гэрээ эзэмшигчидтэй тогтоосон уг худалдан авагчийн харилцаа нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана. Худалдан авагчийн харилцаа болох уг биет бус хөрөнгөнд УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* ба УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийг мөрдөнө.

Заавал биелүүлэх хэлцлээс бусад арга хэрэгслээр дамжуулан үүссэн худалдан авагчийн харилцаа

- ҮЖ221. Заавал биелүүлэх хэлцлээс үүсээгүй, худалдан авалтаар олж эзэмшсэн худалдан авагчийн харилцааг салган тусгаарлах боломжтой учраас ямартаа ч тодорхойлох боломжтой байж болох юм. Бусад байгууллагууд нь заавал биелүүлэх хэлцлээс өөр бусад арга хэрэгслээр дамжуулан үүссэн тухайн төрлийн худалдан авагчийн харилцааг борлуулсан буюу бусад байдлаар шилжүүлсэн гэдгийг илэрхийлэн харуулах ижил буюу төсөөтэй хөрөнгийн арилжааны ажил гүйлгээ нь уг харилцааг салган тусгаарлах боломжтой гэсэн нотолгоогоор хангана.

*Урлагтай холбоотой биет бус хөрөнгө*

- ҮЖ222. Урлагтай холбоотой биет бус хөрөнгийн жишээнд дараах зүйлс хамаарна:

<b>Анги</b>	<b>Суурь</b>
Жүжиг, дуурь, баллет	Заавал биелүүлэх хэлцэл
Ном, сэтгүүл, сонин ба уран зохиолын бусад бүтээл	Заавал биелүүлэх хэлцэл
Хөгжмийн зохиол, дууны шүлэг, зар сурталчилгааны ая гэх мэт хөгжмийн бүтээл	Заавал биелүүлэх хэлцэл
Уран зураг ба фото зураг	Заавал биелүүлэх хэлцэл
Видео ба аудио дүрс бичлэгийн материал, үүн дотроо сүүдэр ший буюу кино, хөгжмийн видео, телевизийн хөтөлбөр	Заавал биелүүлэх хэлцэл

- ҮЖ223. Худалдан авалтаар олж эзэмшсэн урлагтай холбоотой хөрөнгө нь заавал биелүүлэх хэлцлээс (үүн дотроо, гэрээний эрхээс) эсвэл зохиогчийн



## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

эрхээр хамгаалагдсан гэх мэт хууль ёсны эрхээс үүссэн бол түүнийг тодорхойлох боломжтой байна. Эзэмшигч нь зохиогчийн эрхийг шилжүүлэлтийн хэлцлээр бүхэлд нь, эсвэл лицензийн гэрээгээр хэсэгчлэн шилжүүлж болно. Нэгтгэгч нь зохиогчийн эрх болох биет бус хөрөнгийг, түүнчлэн ижил төсөөтэй ашиглалтын хугацаатай бол аливаа холбогдох шилжүүлэлтийн гэрээ буюу лицензийн гэрээг нэг хөрөнгө байдлаар хүлээн зөвшөөрөхийг хориглохгүй.

### *Заавал биелүүлэх хэлцэлд үндэслэсэн биет бус хөрөнгө*

ҮЖ224. Заавал биелүүлэх хэлцэлд үндэслэсэн биет бус хөрөнгө нь уг заавал биелүүлэх хэлцлээс үүсэх эрхийн үнэ цэнийг илэрхийлдэг. Худалдан авагчидтай байгуулсан заавал биелүүлэх хэлцэл нь заавал биелүүлэх хэлцэлд үндэслэсэн биет бус хөрөнгийн нэг төрөл юм. Хэрэв заавал биелүүлэх хэлцлийн нөхцөл нь өр төлбөр үүсэхэд хүргэж байвал (жишээлбэл; үйл ажиллагааны түрээс буюу худалдан авагчтай байгуулсан заавал биелүүлэх хэлцлийн нөхцөл нь зах зээлийн нөхцөлтэй харьцуулахад тааламжгүй бол) нэгтгэгч нь үүнийг худалдан авалтаар хариуцсан өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө. Заавал биелүүлэх хэлцэлд үндэслэсэн биет бус хөрөнгийн жишээнд дараах зүйлс хамаарна:

<b>Анги</b>	<b>Суурь</b>
Лиценз олголт, эрхийн шимтгэл ба түр зогсоох хэлцэл	Заавал биелүүлэх хэлцэл
Зар сурталчилгаа, барилгын ажил, менежмент, үйлчилгээ, бараа нийлүүлэлтийн заавал биелүүлэх хэлцэл	Заавал биелүүлэх хэлцэл
Түрээсийн гэрээ (тухайн худалдан авсан үйл ажиллагаа нь түрээслэгч эсвэл түрээслүүлэгч эсэхээс үл хамаарах)	Заавал биелүүлэх хэлцэл
Барилгын ажлын зөвшөөрөл	Заавал биелүүлэх хэлцэл
Франчайзын гэрээ	Заавал биелүүлэх хэлцэл
Үйл ажиллагааны болон өргөн нэвтрүүлгийн эрх	Заавал биелүүлэх хэлцэл
Моргейжийн үйлчилгээний заавал биелүүлэх хэлцэл гэх мэт үйлчилгээний заавал биелүүлэх хэлцэл	Заавал биелүүлэх хэлцэл
Ажил эрхлэлтийн заавал биелүүлэх хэлцэл	Заавал биелүүлэх хэлцэл
Өрөмдлөг, усжуулалт, агааржуулалт, мод огтлолт, замын эрх гэх мэт ашиглах эрхүүд	Заавал биелүүлэх хэлцэл

Моргейжийн үйлчилгээний заавал биелүүлэх хэлцэл гэх мэт үйлчилгээний заавал биелүүлэх хэлцэл

ҮЖ225. Санхүүгийн хөрөнгөнд үйлчилгээ үзүүлэх заавал биелүүлэх хэлцэл нь заавал биелүүлэх хэлцэлд үндэслэсэн биет бус хөрөнгийн нэг төрөл юм. Хэдийгээр үйлчилгээ үзүүлэлт нь бүх санхүүгийн хөрөнгөнд угаасаа

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

байдаг боловч дараах зүйлсийн аль нэгээр түүнийг тусдаа хөрөнгө (эсвэл өр төлбөр) болгодог:

(а) Үйлчилгээ үзүүлэлтийг хадгалан үлдэхийн хамтаар тухайн хөрөнгийг борлуулах буюу үнэт цаасжуулснаар уг заавал биелүүлэх хэлцэлд тэрхүү суурь санхүүгийн хөрөнгөөс салган тусгаарлах тохиолдолд;

(б) Тусдаа худалдан авалт ба үйлчилгээний ашиглалтаар дамжуулан.

ҮЖ226. Үйлчилгээ үзүүлэлтийг хадгалан үлдэхийн хамтаар моргейжийн зээл, кредит картын авлага буюу бусад санхүүгийн хөрөнгийг худалдан авалтаар олж эзэмшсэн тохиолдолд тэдгээр үйлчилгээ үзүүлэх эрхийн бодит үнэ цэнийг тухайн олж эзэмшсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтэнд тусган оруулах учраас уг үйлчилгээ үзүүлэх угийн эрх нь тусдаа биет бус хөрөнгө болохгүй.

Ажил эрхлэлтийн заавал биелүүлэх хэлцэл

ҮЖ227. Ажил олгогчийн зүгээс авч үзэхэд үр өгөөжтэй заавал биелүүлэх хэлцэл болох ажил эрхлэлтийн заавал биелүүлэх хэлцлийн үнэ тогтоолт нь зах зээлийн нөхцөлтэй харьцуулахад тааламжтай байдаг учраас энэхүү заавал биелүүлэх хэлцэл нь заавал биелүүлэх хэлцэлд суурилсан биет бус хөрөнгийн нэг төрөл юм.

Ашиглах эрх

ҮЖ228. Ашиглах эрхэд өрөмдлөг, усжуулалт, агааржуулалт, мод огтлолт, замын эрх зэрэг хамаарна. Ашиглах зарим эрх нь гүүдвилээс тусдаа тайлагнах заавал биелүүлэх хэлцэлд үндэслэсэн биет бус хөрөнгө юм. Өөр зарим ашиглах эрх нь биет бус хөрөнгө гэхээсээ илүү биет хөрөнгийн шинж чанартай байж болно. Нэгтгэгч нь ашиглах эрхийг тэдний мөн чанарт үндэслэн тайлагнах хэрэгтэй.

*Технологид үндэслэсэн биет бус хөрөнгө*

ҮЖ229. Технологид үндэслэсэн биет бус хөрөнгийн жишээнд дараах зүйлс хамаарна:

<b>Анги</b>	<b>Суурь</b>
Патентжуулсан технологи	Заавал биелүүлэх хэлцэл
Компьютерийн программ хангамж ба маск ажил <sup>3</sup>	Заавал биелүүлэх хэлцэл
Патентжуулаагүй технологи	Заавал биелүүлэх хэлцэл байхгүй

<sup>3</sup> Mask work-Маск ажил гэдэг нь АНУ-ын Оюуны өмчийн хуульд тодорхойлсноор, харилцан уялдсан схемийн хоёр буюу гурван хэмжээст зохион байгуулалт буюу ерөнхий зураглал юм. Өөрөөр хэлбэл, энэ нь транзистор гэх мэт хагас дамжуулагч төхөөрөмж болон цахилгаан эсэргүүцэгч, харилцан холболт гэх мэт идэвхигүй цахим бүрэлдэхүүн хэсгүүдийн чипийн зохион байгуулалт юм. Ред.Ч.Д.

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

Мэдээний сан, үүн дотроо эрхийн бүртгэл	Заавал биелүүлэх хэлцэл байхгүй
Нууц томъёо, процесс, жор гэх мэт худалдааны нууц	Заавал биелүүлэх хэлцэл

Компьютерийн программ хангамж ба маск ажил

ҮЖ230. Патент буюу зохиогчийн эрх гэх мэт хууль ёсоор хамгаалагдсан бөгөөд худалдан авалтаар олж эзэмшсэн компьютерийн программ хангамж ба программын формат нь биет бус хөрөнгө гэж тодорхойлох заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангадаг.

ҮЖ231. Маск ажил нь цуврал тэмдэгтүүд буюу харилцан уялдсан схем тул зөвхөн уншихад зориулагдсан санах ойн чипэнд байнга хадгалагддаг программ хангамж юм. Маск ажил нь хууль ёсны хамгаалалттай байж болно. Худалдан авалтаар олж эзэмшсэн, хууль ёсны хамгаалалттай маск ажил нь биет бус хөрөнгө гэж тодорхойлох заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангадаг.

Мэдээний сан, үүн дотроо эрхийн бүртгэл

ҮЖ232. Мэдээний сан нь ихэвчлэн цахим хэлбэрээр (компьютерийн дискэнд буюу файлд гэх мэтээр) хадгалагддаг мэдээллийн цуглуулга юм. Зохиогчийн эх бүтээлүүдийг агуулсан мэдээний санг зохиогчийн эрхээр хамгаалж болно. Худалдан авалтаар олж эзэмшсэн бөгөөд зохиогчийн эрхээр хамгаалагдсан мэдээний сан нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангадаг. Гэвч мэдээний сан нь үйлчилгээний хэрэглэгчдийн жагсаалт гэх мэт байгууллагын хэвийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон мэдээлэл эсвэл шинжлэх ухааны мэдээ, зээлийн мэдээлэл гэх мэт тусгай мэдээллийг ихэвчлэн агуулсан байдаг. Зохиогчийн эрхээр хамгаалагдаагүй мэдээний санг бүхэлд нь буюу хэсэгчлэн худалдан арилжиж, лицензээр эзэмшүүлж эсвэл түрээслүүлж болох бөгөөд ямагт ингэж ашигладаг. Иймээс мэдээний сангийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь хууль ёсны эрхээс үүсдэггүй боловч худалдан авалтаар олж эзэмшсэн мэдээний сан нь салган тусгаарлах шалгуурыг хангадаг.

ҮЖ233. Эрхийн бүртгэл нь тодорхой газарзүйн бүс дэх зурвас газрын эрхэд нөлөөлөх бүх зүйлсийн түүхэн бүртгэлээс бүрддэг. Эрхийн бүртгэл гэсэн хөрөнгийг арилжааны ажил гүйлгээгээр бүрэн буюу хэсэгчлэн худалдах ба худалдан авдаг буюу лицензээр ашиглуулдаг. Иймээс худалдан авалтаар олж эзэмшсэн эрхийн бүртгэл нь салган тусгаарлах шалгуурыг хангадаг.

Нууц томъёо, процесс, жор гэх мэт худалдааны нууц

ҮЖ234. Худалдааны нууц нь (а) нийтэд мэдэгдээгүй зүйлээс бодит буюу боломжит эдийн засгийн бие даасан үнэ цэнийг бий болгодог, ба (б) түүний нууц байдлыг хадгалахын тулд тухайн нөхцөл байдалд ул үндэслэлтэй хүчин чармайлт гаргахыг шаардаг мэдээлэл бөгөөд үүнд

томъёо, загвар, жор, бүтээл, программ, төхөөрөмж, арга, арга зүй, процесс хамаарна.<sup>4</sup> Худалдан авалтаар олж эзэмшсэн худалдааны нууцын ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг хууль ёсоор хамгаалсан бол уг хөрөнгө нь заавал биелүүлэх хэлцлийн шалгуурыг хангана. Хууль ёсоор хамгаалагдаагүй бол салган тусгаарлах шалгуур зөвхөн хангагдсан үед худалдан авалтаар олж эзэмшсэн худалдааны нууцыг тодорхойлж болох бөгөөд салган тусгаарлах шалгуур хангагдах нилээд их магадлалтай байдаг.

### **Худалдан авалтын үеийн хяналтын бус хувь оролцоо (ХБХО)-ны хэмжилт**

*УСНББОУС 40-ийн 73-р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ235. Худалдан авалтын үед ХБХО-ны бүрэлдэхүүн хэсгүүдийн уг худалдан авалтын өдрөөрх хэмжилтийг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

*ХБХО-ны хэмжилт, үүн дотроо Давуу эрхийн хувьцаа*

ҮЖ236. ЗБ нь 100 ширхэг давуу эрхийн хувьцаа гаргасан бөгөөд өмч гэж ангилсан. Уг давуу эрхийн хувьцаа нь нэгжийн 1 ТН-ийн нэрлэсэн үнэтэй байв. Давуу эрхийн хувьцаа нь энгийн хувьцаа эзэмшигчдэд аливаа ногдол ашиг төлөхөөс өмнө түрүүлж ногдол ашиг авах эрхийг өөрийн эзэмшигчдээ олгодог. ЗБ-ыг татан буулгах үед тухайн давуу эрхийн хувьцаа эзэмшигчид нь хуваарилах боломжтой хөрөнгүүдээс нэгж хувьцаа бүрд 1 ТН-ийг энгийн хувьцаа эзэмшигчдээс түрүүлж авах эрхтэй байдаг. Давуу эрхийн хувьцааны эзэмшигчид нь татан буулгалттай холбоотойгоор өөр ямар нэг эрхгүй.

ҮЖ237. НБ нь ЗБ-ын бүх энгийн хувьцааг худалдаж авсан. Энэ ажил гүйлгээгээр НБ нь ЗБ-ын хяналтыг олж авсан бөгөөд УСНББОУС 40-ийн 9-14 ба МЗУ19-МЗУ50-р параграфт дурдсан, заавар удирдамжийг ашиглан уг нэгдлийн эдийн засгийн мөн чанарын талаар хийсэн шинжилгээ нь энэхүү ажил гүйлгээ худалдан авалт болохыг баталж байна. Давуу эрхийн хувьцааны уг худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ нь 120 ТН байна.

ҮЖ238. Худалдан авалт нэг бүрийн хувьд нэгтгэгч нь худалдан авсан үйл ажиллагаан дахь одоогийн өмчлөлийн хувь оролцоо болох тухайн хяналтын бус хувь оролцооны бүрэлдэхүүн хэсгүүдийг худалдан авалтын өдрөөр хэмжих бөгөөд татан буулгах үед бодит үнэ цэнээр, эсвэл тэрхүү худалдан авсан үйл ажиллагааны тодорхойлогдох цэвэр хөрөнгийн хүлээн зөвшөөрсөн дүн дэх одоогийн өмчийн хэрэглүүрийн хувь тэнцүүлсэн хэсгээр тооцож, уг байгууллагын цэвэр хөрөнгийн хувь тэнцүүлсэн хэсгийг авах эрхийг тэдгээр хяналтын бус хувь оролцооны эзэмшигчдэд олгоно гэж УСНББОУС 40-ийн 73-р параграфт заасан байдаг. УСНББОУС-аар өөр хэмжилтийн суурь хэрэглэхийг шаардсанаас бусад тохиолдолд хяналтын бус оролцооны бусад бүх бүрэлдэхүүн

---

<sup>4</sup> Мелвин Сименски ба Ланнинг Брайер, “Худалдаа арилжааны ажил гүйлгээн дэх оюуны өмчийн гүйцэтгэх шинэ үүрэг” (Нью Йорк: Жон Вилий энд Санс, 1998 он), 293-р хуудас.

хэсгүүдийг худалдан авалтын өдөр тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

- ҮЖ239. ЗБ-ын давуу эрхийн хувьцаатай холбоотой хяналтын бус хувь оролцоо нь тухайн байгууллагыг татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн авах эрхийг эзэмшигчиддээ олгодоггүй учраас УСНББОУС 40-ийн 73-р параграфт заасан, хэмжилтийн сонголтыг хэрэглэх шалгуурыг хангадаггүй. Нэгтгэгч нь давуу эрхийн хувьцааг түүний худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ болох 120 ТН-ээр хэмжинэ.

#### *Эхний хувилбар*

- ҮЖ240. ЗБ-ыг татан буулгах үед давуу эрхийн хувьцаа нь тухайн хуваарилах боломжтой хөрөнгөөс хувь тэнцүүлэн авах эрхийг эзэмшигчиддээ олгодог гэж үзье. Давуу эрхийн хувьцааны эзэмшигчид нь татан буулгалтын үед энгийн хувьцааны эзэмшигчидтэй ижил тэнцүү эрх ба зэрэглэлтэй байна. Давуу эрхийн хувьцааны худалдан авалтын өдрийн бодит үнэ цэнэ нь одоо 160 ТН болсон бөгөөд ЗБ-ын тодорхойлогдох цэвэр хөрөнгийн хүлээн зөвшөөрсөн дүнгээс тухайн давуу эрхийн хувьцаанд хамаарах хувь тэнцүүлсэн хэсэг нь 140 ТН гэж үзье.

- ҮЖ241. Давуу эрхийн хувьцаа нь УСНББОУС 40-ийн 73-р параграфт заасан хэмжилтийн сонголтыг хийх шалгуурыг хангана. НБ нь давуу эрхийн хувьцааг худалдан авалтын өдрийн 160 ТН-ийн бодит үнэ цэнэ эсвэл уг худалдан авсан үйл ажиллагааны тодорхойлогдох цэвэр хөрөнгийн хүлээн зөвшөөрсөн дүнгээс хувь тэнцүүлсэн хэсэг болох 140 ТН-ийн аль нэгээр хэмжих сонголт хийж болно.

#### *Хоёр дахь хувилбар*

- ҮЖ242. ЗБ нь өөрийн ажиллагчиддаа цалин урамшуулал болгон мөн хувьцааны опцион гаргаж, олгосон гэж үзье. Хувьцааны опционыг өмчөөр ангилж, уг худалдан авалтын өдрөөр баталгаажуулсан. Эдгээр опцион нь одоогийн өмчлөлийн хувь оролцоог илэрхийлэхгүй бөгөөд татан буулгалтын үед уг ЗБ-ын цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлсэн хэсгийг авах эрхийг өөрийн эзэмшигчиддээ олгодоггүй. Хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу тооцсон хувьцааны опционы бодит үнэ цэнэ нь уг худалдан авалтын өдөр 200 ТН байсан. Хувьцааны опционы хугацаа нь худалдан авалтын өдрөөр дуусаагүй байгаа бөгөөд НБ нь тэдгээрийг орлуулаагүй.

- ҮЖ243. УСНББОУС-уудаар өөр хэмжилтийн суурь ашиглахыг шаардсанаас бусад тохиолдолд УСНББОУС 40-ийн 73-р параграф нь ийм хувьцааны опционыг тэдгээрийн худалдан авалтын өдрийн бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг. Нэгтгэгч нь уг худалдан авсан үйл ажиллагааны хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээтэй холбоотой өмчийн хэрэглүүрийг хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг нягтлан бодох

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу хэмжихээр УСНББОУС 40-ийн 84-р параграфт заасан байдаг.

ҮЖ244. Нэгтгэгч нь энэхүү хувьцааны опционтой холбоотой хяналтын бус хувь оролцоог тэдгээрийн бодит үнэ цэнэ болох 200 ТН-ээр хэмжинэ.

### Төлөх татварыг худалдан авалтаар чөлөөлөх

*Худалдан авалтын үеийн татвараас чөлөөлөлтийг УСНББОУС 40-ийн 78-79 ба МЗУ85-МЗУ87-р параграфыг дагаж мөрдсөнөөр тайлагнасны үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ245. Худалдан авсан үйл ажиллагааны татварын өр төлбөрийн тодорхой хэсгийг тэрхүү худалдан авалтын нөхцлийн нэг хэсг байдлаар чөлөөлсөн худалдан авалтын тайлагналыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

ҮЖ246. Засгийн газрыг төлөөлөн үйл ажиллагаа явуулж буй засгийн газрын яам нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж болох ЗБ-ыг 20X4 оны 01 дүгээр сарын 01-нд 575 ТН-ийн мөнгөн хөрөнгөөр худалдаж авсан. Энэхүү худалдан авалтын үр дүнд НБ нь цар хүрээний хэмнэлтээр өртөг зардлыг бууруулна гэж хүлээж байна. Худалдан авсан хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь дараах байдалтай байна:

<b>Худалдан авсан хөрөнгө ба хариуцсан өр төлбөр</b>	<b>ТН</b>
Санхүүгийн хөрөнгө	265
Бараа материал	5
Үндсэн хөрөнгө	640
Тодорхойлогдох биет бус хөрөнгө	12
Санхүүгийн өр төлбөр	(320)
Татварын өр төлбөр	(40)
Цэвэр хөрөнгийн дүн	<u>562</u>

ҮЖ247. НБ нь ЗБ-ыг худалдан авахын тулд төлсөн үнэ (575 ТН) ба ЗБ-ын цэвэр хөрөнгө (562 ТН)-ийн зөрүү болох 13 ТН-ээр гүүдвлийг хүлээн зөвшөөрнө.

ҮЖ248. Худалдан авалтын нөхцлийн нэг хэсэг болгон Засгийн газар нь ЗБ-ын татварын өр төлбөрийн 50 хувийг чөлөөлөхийг ТА (татварын алба)-гаас шаардсан гэж үзье. Худалдан авсан хөрөнгө болон хариуцсан өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь одоо дараах байдалтай болно:

<b>Худалдан авсан хөрөнгө ба хариуцсан өр төлбөр</b>	<b>ТН</b>
Санхүүгийн хөрөнгө	265
Бараа материал	5
Үндсэн хөрөнгө	640
Тодорхойлогдох биет бус хөрөнгө	12
Санхүүгийн өр төлбөр	(320)
Татварын өр төлбөр	(20)
Цэвэр хөрөнгийн дүн	<u>582</u>

- ҮЖ249. НБ нь ЗБ-ыг худалдан авахын тулд төлсөн үнэ (575 ТН) ба ЗБ-ын цэвэр хөрөнгө (582 ТН)-ийн зөрүү болох 7 ТН-ийн олзыг хүлээн зөвшөөрнө. Нэгтгэгч нь үлдсэн татварын өр төлбөрийг орлогын албан татварыг зохицуулдаг нягтлан бодох бүртгэлийн олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу тайлагнана.
- ҮЖ250. ТА нь татварын авлагыг УСНББОУС 23-ын дагуу тайлагнах бөгөөд уг чөлөөлөгдсөн татварын хувьд залруулгыг хүлээн зөвшөөрнө.

### **Худалдан авалтын үеийн тохиролцоот худалдан авалтын олз**

*Худалдан авалтын үед тохиролцоот худалдан авалтын олзыг УСНББОУС 40-ийн 85-90-р параграфыг дагаж мөрдсөнөөр хүлээн зөвшөөрч, хэмжээний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

- ҮЖ251. Тохиролцоот худалдан авалтын олз хүлээн зөвшөөрсөн худалдан авалтын тайлагналыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.
- ҮЖ252. НБ нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж болох ЗБ-ын өмчийн хувь оролцооны 80 хувийг 20Х5 оны 01 дүгээр сарын 01-нд 150 ТН-ийн мөнгөн хөрөнгөөр худалдаж авсан. ЗБ-ын хуучин эзэд нь уг байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтаа тусгайлан заасан өдрөөр борлуулах шаардлагатай болсон учраас тэд боломжит олон худалдан авагчдад уг ЗБ-ыг танилцуулан зах зээлд гаргах хангалттай хугацаа байгаагүй. НБ-ын удирдлага нь тусдаа хүлээн зөвшөөрч болох уг худалдан авсан тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийг тэрхүү худалдан авалтын өдрөөр УСНББОУС 40-ийн шаардлагуудын дагуу анх хүлээн зөвшөөрсөн. Тодорхойлогдох хөрөнгийг 250 ТН-ээр, хариуцсан өр төлбөрийг 50 ТН-ээр хэмжсэн. НБ нь хараат бус зөвлөгч хөлслөн ажилуулсан бөгөөд уг зөвлөгч нь ЗБ дахь 20 хувийн хяналтын бус хувь оролцооны бодит үнэ цэнийг 42 ТН гэж тодорхойлсон.
- ҮЖ253. ЗБ-ын тодорхойлогдох цэвэр хөрөнгийн дүн (250ТН - 500 ТН = 200 ТН гэж тооцоолсон) нь шилжүүлсэн төлбөрийн бодит үнэ цэнэ дээр ЗБ дахь хяналтын бус хувь оролцооны бодит үнэ цэнийг нэмсэн дүнгээс давж илүү гарсан. Иймээс НБ нь уг худалдан авсан хөрөнгө, хариуцсан өр төлбөрийг тодорхойлж, хэмжих болон ЗБ дахь хяналтын бус хувь оролцоо ба шилжүүлсэн төлбөрийн аль алины бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан горимуудыг нягталж шалгасан. Ингэж нягталж шалгасны дараа НБ нь тэдгээр горимууд болон үр дүн болох хэмжилтүүд тохиромжтой гэж үзсэн. НБ нь уг 80 хувийн хувь оролцооны худалдан авалтын олзыг дараах байдлаар хэмжсэн:

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

	ТН
Худалдан авсан тодорхойлогдох цэвэр хөрөнгийн дүн (ТН250-ТН-50)	200
Хасах: 3Б дахь уг НБ-ын 80 хувийн хувь оролцооны төлөө шилжүүлсэн төлбөрийн бодит үнэ цэнэ; нэмэх	150
3Б дахь хяналтын бус хувь оролцооны бодит үнэ цэнэ	42
	192
80 хувийн хувь оролцооны тохиролцоот худалдан авалтын олз	8

ҮЖ254. НБ нь 3Б-ын худалдан авалтыг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа дараах байдлаар тайлагнана:

	ТН	ТН
Дебит Худалдан авсан тодорхойлогдох хөрөнгө	250	
Кредит Мөнгө		150
Кредит Хариуцсан өр төлбөр		50
Кредит Тохиролцоот худалдан авалтын олз		8
Кредит Өмч – 3Б дахь хяналтын бус хувь оролцоо		42

ҮЖ255. Хэрэв нэгтгэгч нь 3Б дахь хяналтын бус хувь оролцоог уг худалдан авсан үйл ажиллагааны тодорхойлогдох цэвэр хөрөнгө дэх өөрийн хувь тэнцүүлсэн оролцоонд үндэслэн хэмжих сонголт хийсэн бол тэрхүү хяналтын бус хувь оролцооны хүлээн зөвшөөрсөн дүн нь 40 ТН (200 ТН х 0.20) болно. Харин тохиролцоот худалдан авалтын олз нь 10 ТН (200 ТН - (150 ТН + 40 ТН)) болох юм.

**Худалдан авалтын үеийн хэмжилтийн хугацаа**

*УСНББОУС 40-ийн 103-108 -р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ256. Худалдан авалтын анхны тайлагнал нь уг худалдан авалтыг хийсэн санхүүгийн тайлант үеийн эцэст бүрэн дуусаагүй бол нэгтгэгч нь тухайн тайлагнал хараахан дуусаагүй байгаа зүйлсийн хувьд нөхцөлт дүнг өөрийн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 40-ийн 103-р параграфтаар шаардсан байдаг. Худалдан авалтын өдрөөр оршин байсан бөгөөд хэрэв мэдэгдсэн бол уг өдрөөр хүлээн зөвшөөрсөн дүнгийн хэмжилтэнд нөлөөлөх байсан баримт материал болон нөхцөл байдлын талаар олж авсан шинэ мэдээллийг тусгахад шаардлагатай тэрхүү нөхцөлт дүнд хийх тохируулгыг тухайн нэгтгэгч нь хэмжилтийн хугацааны туршид хүлээн зөвшөөрнө. Нэгтгэгч нь ийм тохируулгыг уг худалдан авалтын өдрөөр тухайн худалдан авалтын тайлагналыг эцэслэн дуусгасан байдлаар хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 40-ийн



## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

107-р параграфээр шаарддаг. Хэмжилтийн хугацааны тохируулгыг ашиг, алдагдалд тусгахгүй.

- ҮЖ257. НБ нь 20X7 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр ЗБ-ыг худалдан авсан гэж үзье. НБ нь нэгдлээр олж эзэмшсэн үндсэн хөрөнгийн зүйлийг үнэлүүлэхээр хараат бус үнэлгээчин ажиллуулах гэж байгаа бөгөөд уг үнэлгээ нь 20X7 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангаа гаргахыг НБ зөвшөөрөх үед бүрэн дуусаагүй байсан. 20X7 оны жилийн эцсийн санхүүгийн тайландаа НБ нь уг хөрөнгийг 30,000 ТН-ийн нөхцөлт бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрсөн. Худалдан авалтын өдөр уг үндсэн хөрөнгийн зүйл нь таван жилийн үлдэх ашиглалтын хугацаатай байсан. Худалдан авалтын өдрөөс хойш таван сарын дараа, НБ нь хараат бус үнэлгээг хүлээн авсан бөгөөд тухайн хөрөнгийн худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг энэхүү үнэлгээгээр 40,000 ТН гэж тооцоолсон байсан.
- ҮЖ258. 20X8 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайландаа НБ нь өмнөх 20X7 оны мэдээллийг дараах байдлаар буцаах горимоор залруулсан:
- (а) 20X7 оны 12 дугаар сарын 31-нээрх үндсэн хөрөнгийн дансны үнийг 9,500 ТН-ээр нэмэгдүүлсэн. Хэрэв худалдан авалтын өдрөөр хөрөнгийг тухайн бодит үнэ цэнээр хэмжсэн бол тэрхүү өдрөөс хойш хүлээн зөвшөөрөх байсан нэмэлт элэгдлийг (гурван сарын элэгдэл 500 ТН) уг худалдан авалтын өдрөөрх 10,000 ТН-ийн үнэлгээний тохируулгаас хасах замаар залруулгын дүнг хэмжинэ.
  - (б) 20X7 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гүүдвилийн дансны үнийг 10,000 ТН-ээр бууруулсан.
  - (в) 20X7 оны элэгдлийн зардлыг 500 ТН-ээр нэмэгдүүлсэн.
- ҮЖ259. УСНББОУС 40-ийн 124-р параграфын дагуу НБ нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Үндсэн хөрөнгийн үнэлгээг хараахан хүлээн аваагүй байсан учраас тухайн худалдан авалтын анхны тайлагнал нь бүрэн дуусаагүй гэдгийг өөрийн 20X7 оны санхүүгийн тайланд тодруулах.
  - (б) Тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн нөхцөлт дүнгийн тохируулгын дүн ба тайлбарыг 20X8 оны санхүүгийн тайландаа тодруулах. Иймээс НБ нь худалдан авалтын өдрөөрх үндсэн хөрөнгийн зүйлийн бодит үнэ цэнийг 9,500 ТН-ээр нэмэгдүүлэхийн тулд 20X7 оны зэрэгцүүлэгдэх мэдээллийг буцаах горимоор залруулсан гэдгийг тодруулна. Энэхүү 9,500 ТН нь гүүдвилийн 10,000 ТН-ийн бууралт ба элэгдлийн зардлын 500 ТН-ийн нэмэгдүүлэлтээр харилцан нөхөгдөнө.

**Худалдан авалтын ажил гүйлгээний нэг хэсэг болох зүйлсийг тодорхойлох**

*Өмнө оршин байсан харилцааг дуусвар болгох - Зээл*

*УСНББОУС 40-ийн 109-110, МЗУ98-МЗУ101-р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ260. НБ нь ЗБ-д таван жилийн хугацаатай, тогтмол хүүтэй, 100 ТН-ийн зээл олгосон. Зээлийн үндсэн дүнг хугацааны эцэст, харин хүүг улирал тутам төлнө. Зээлийн гэрээний хугацаа дуусахад хоёр жил дутуу байхад НБ нь ЗБ-ыг худалдаж авсан.

ҮЖ261. ЗБ-ын нийт бодит үнэ цэнэд НБ-тай байгуулсан зээлийн гэрээний бодит үнэ цэнэ болох 90 ТН-ийн санхүүгийн өр төлбөрийг тусган оруулсан. НБ-ын санхүүгийн тайлан дахь харгалзах санхүүгийн хөрөнгийн дансны үнэ (зээлийн хорогдуулсан өртөг) нь уг худалдан авалтын өдөр 100 ТН байсан.

ҮЖ262. Энэ жишээнд НБ нь 10ТН-ийн гарз тооцоолсон. НБ-ын хариуцсан санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ ба түүний өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан, харгалзах санхүүгийн хөрөнгийн дансны үнийн хоорондох зөрүүгээр уг гарзыг тооцоолно. Нэгтгэсэн санхүүгийн тайландаа тухайн НБ нь өөрийн санхүүгийн хөрөнгө (100 ТН)-ийг ЗБ-ын санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ (90 ТН)-ээс хасаж, устган цэвэрлэх бөгөөд зөрүү нь НБ-ын гарзыг илэрхийлнэ.

*Өмнө оршин байсан харилцааг дуусвар болгох - Шилжүүлэг*

*УСНББОУС 40-ийн 109-110, МЗУ98-МЗУ101-р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ263. 20Х7 оны 01 дүгээр сарын 01-нд НБ нь ЗБ-ыг худалдан авсан. Үүнээс өмнө буюу 20Х6 оны 10 дугаар сарын 01-нд НБ нь тохиролцсон тооны сургалт явуулахад зориулан ЗБ-д 800 ТН-ийн буцалтгүй тусламж олгосон.

ҮЖ264. Хийгдээгүй сургалтын тоогоор хувь тэнцүүлэн энэхүү буцалтгүй тусламжийг буцаан төлөх нөхцөлтэй. Худалдан авалтын өдрөөр ЗБ нь тохиролцсон тооны сургалтын дөрөвний нэгийг явуулсан бөгөөд өөрийн гүйцэтгээгүй үүргийн хувьд 600 ТН-ийн өр төлбөрийг УСНББОУС 23-ын дагуу хүлээн зөвшөөрсөн. ЗБ нь сургалтыг явуулахгүй байхаас явуулах нь илүү их магадлалтай гэж НБ нь өөрийн өмнөх туршлагад үндэслэн дүгнэсэн. Иймээс НБ-д нөөцийг буцаан олгох магадлал багатай тул НБ нь уг буцалтгүй тусламжийн хувьд хөрөнгө хүлээн зөвшөөрөөгүй, харин 800 ТН-ийг бүгдийг нь зардал гэж тайлагнасан.

ҮЖ265. Энэ жишээнд НБ нь 600ТН-ийн олз тооцоолсон. Худалдан авалтын үр дүнд гуравдагч талын өмнө хүлээх ямар нэг үүрэг байхгүй учраас үл хүлээн зөвшөөрсөн тэрхүү хариуцсан өр төлбөрөөр олзыг тооцоолно.

ҮЖ266. Энэ жишээнд НБ нь харгалзах хөрөнгийг хүлээн зөвшөөрөөгүй; хэрэв НБ нь харгалзах хөрөнгийг өмнө нь хүлээн зөвшөөрсөн бол түүнийг уг худалдан авалтын өдөр үл хүлээн зөвшөөрөх бөгөөд тэрхүү үл хүлээн зөвшөөрсөн дүнг олз, гарзын тооцоололд тусган оруулах байсан.

*Өмнө оршин байсан харилцааг дуусвар болгох - Бэлтгэн нийлүүлэх гэрээ*

*УСНББОУС 40-ийн 109-110, МЗУ98-МЗУ101-р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ267. НБ нь таван жилийн хугацаанд тогтмол үнээр бэлтгэн нийлүүлэх гэрээний дагуу ЗБ-аас электрон эд ангиудыг худалдан авдаг. Уг тогтмол үнэ нь ижил төсөөтэй электрон эд ангиудыг бусад бэлтгэн нийлүүлэгчээс НБ-ын худалдан авч болох үнээс одоогийн байдлаар өндөр байна. Энэхүү бэлтгэн нийлүүлэх гэрээний дагуу НБ нь эхний таван жилийн хугацаа дуусахаас өмнө зөвхөн 6 сая ТН-ийн торгууль төлснөөр гэрээг цуцлах боломжтой юм. Тухайн бэлтгэн нийлүүлэх гэрээний дуусахад гурван жил дутуу байхад НБ нь ЗБ-ыг худалдан авахын тулд 50 сая ТН төлсөн бөгөөд энэ дүн нь зах зээлийн бусад оролцогчдын төлөхөд бэлэн байгаа дүнд үндэслэсэн уг ЗБ-ын бодит үнэ цэнэ юм.

ҮЖ268. НБ-тай байгуулсан уг бэлтгэн нийлүүлэх гэрээний бодит үнэ цэнэд хамаарах 8 сая ТН-ийг ЗБ-ын нийт бодит үнэ цэнэд тусган оруулсан. Энэхүү 8 сая ТН нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд: үнэ тогтоолт нь ижил буюу адилтгах зүйлсийн (борлуулалтын хүчин чармайлт, худалдан авагчийн харилцаа гэх мэтийн хувьд) одоогийн зах зээлийн ажил гүйлгээний үнэтэй зэрэгцүүлэгдэхүйц учраас “зах зээлийн” түвшнээр байх 3 сая ТН-ийн бүрэлдэхүүн хэсэг, түүнчлэн үнэ тогтоолт нь адилтгах зүйлсийн одоогийн зах зээлийн ажил гүйлгээний үнээс давж илүү гарах учраас НБ-ын хувьд тааламжгүй байх 5 сая ТН-ийн бүрэлдэхүүн хэсэг хамаарна. ЗБ нь энэхүү бэлтгэн нийлүүлэх гэрээтэй холбоотой өөр тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөр байхгүй бөгөөд НБ нь худалдан авалтаас өмнө уг бэлтгэн нийлүүлэх гэрээтэй холбоотойгоор ямар нэг хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрөөгүй.

ҮЖ269. Энэ жишээнд НБ нь тухайн худалдан авалтаас тусад нь 5 сая ТН-ийн гарзыг (6 сая ТН-ийн тогтоосон барагдуулах дүн ба тухайн гэрээ уг нэгтгэгчид тааламжгүй байх дүнгийн аль бага) тооцоолсон. Энэхүү гэрээний “зах зээлийн” түвшнээр байх 3 сая ТН-ийн бүрэлдэхүүн хэсэг нь гүүдвилийн нэг хэсэг юм.

ҮЖ270. Өмнө оршин байсан харилцаатай холбоотойгоор НБ нь өөрийн санхүүгийн тайланд өмнө нь дүн хүлээн зөвшөөрч байсан эсэх нь уг харилцааны үр дүнтэй барагдуулалтын хувьд олз эсвэл гарз гэж хүлээн зөвшөөрөх дүнд нөлөө үзүүлнэ. НБ нь энэхүү худалдан авалтаас өмнө уг бэлтгэн нийлүүлэх гэрээний хувьд 6 сая ТН-ийн өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС-аар шаардсан байсан гэж үзье. Ийм нөхцөлд НБ нь тухайн гэрээний барагдуулалтын 1 сая ТН-ийн (тухайн гэрээний хувьд хэмжсэн 5 сая ТН-ийн гарзаас өмнө хүлээн зөвшөөрсөн 6 сая ТН-

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

ийн гарзыг хассан) олзыг уг худалдан авалтын өдөр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Өөрөөр хэлбэл, НБ нь 6 сая ТН-ийн хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг үнэн хэрэгтээ 5 сая ТН-ээр барагдуулах бөгөөд үүний үр дүнд 1 сая ТН-ийн олз үүснэ.

*Худалдан авалтын үед ажилтнуудад олгох болзошгүй төлбөр*

*УСНББОУС 40-ийн 109-110, МЗУ98, МЗУ102-МЗУ103-р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ271. ЗБ нь нэр дэвшигчийг өөрийн шинэ гүйцэтгэх захирлаар арван жилийн хугацаатай томилсон. Хэрэв энэхүү гэрээний хугацаа дуусахаас өмнө ЗБ-ыг худалдан авсан бол тус ЗБ нь тухайн нэр дэвшигчид 5 сая ТН төлөхөөр гэрээнд заасан. НБ нь үүнээс хойш найман жилийн дараа ЗБ-ыг худалдан авсан. Гүйцэтгэх захирал нь худалдан авалтын өдөр ажилласан хэвээр байсан бөгөөд одоо хэрэгжиж байгаа гэрээний дагуу нэмэлт төлбөр авах юм.

ҮЖ272. Энэ жишээнд, ЗБ нь тухайн нэгдлийн хэлцэл хийгдэж эхлэхээс өмнө ажил эрхлэлтийн гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний зорилго нь гүйцэтгэх захирлыг ажиллуулах явдал байсан. Иймээс НБ буюу тухайн нэгдсэн байгууллагад үр өгөөж бүрдүүлэхийн тулд уг гэрээг үндсэндээ байгуулсан гэсэн нотолгоо байхгүй байна. Иймээс худалдан авалтын аргыг ашиглахдаа уг 5 сая ТН төлөх өр төлбөрийг тусган оруулна.

ҮЖ273. Өөр бусад тохиолдолд, ЗБ нь тэрхүү худалдан авалтын хэлцлийг хийх явцдаа НБ-ын санал болгосны дагуу гүйцэтгэх захиралтай үүнтэй адилтгах гэрээг байгуулж болох юм. Ингэж гэрээ байгуулсан тохиолдолд тэрхүү гэрээний үндсэн зорилго нь гүйцэтгэх захиралд ажлаас халагдалтын тэтгэмж олгох нөхцлийг бүрдүүлж болох бөгөөд уг гэрээ нь ЗБ болон түүний хуучин эздэд биш, харин НБ буюу тухайн нэгдсэн байгууллагад үндсэндээ үр өгөөж бүрдүүлж болох юм. Энэ тохиолдолд НБ нь нэгдлийн дараах өөрийн санхүүгийн тайландаа уг гүйцэтгэх захиралд төлөх өр төлбөрийг худалдан авалтын аргын хэрэглээнээс тусад нь тайлагнана.

**Худалдан авалтын үр дүнд өөрчлөгдөж болох шалгуурт үндэслэн нэгтгэгч эсвэл худалдан авсан үйл ажиллагааны хүлээн авах шилжүүлэг, хөнгөлттэй зээл болон адилтгах өгөөжийн дараагийн тайлант үеийн хэмжилт**

*УСНББОУС 40-ийн 114, МЗУ109-МЗУ111-р параграфыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

ҮЖ274. Худалдан авалтын үр дүнд өөрчлөгдөж болох шалгуурт үндэслэн нэгтгэгчийн хүлээн авсан шилжүүлгийн дараагийн тайлант үеийн тайлагналыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан.

ҮЖ275. Нэг хүнд ногдох орлого нь босго шалгуураас бага орлоготой орон нутгийн захиргаадад 20Х6 оны 01 дүгээр сарын 01-нд үндэсний засгийн газар нь жил тутмын буцалтгүй тусламжийг олгосон. 20Х3 оны 6 дугаар сарын 01-

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

нд орон нутгийн захиргаа болох НБ нь түүнд орлого бий болгох худалдааны цогцолбор болох ЗБ-ыг худалдан авсан. Өөрийн хүн амын нэг хүнд ногдох орлогод үндэслэн НБ нь 500 ТН-ийн буцалтгүй тусламжийг өмнө нь хүлээн авсан байсан.

- ҮЖ276. 20Х3 оны 6 дугаар сарын 01-нд ЗБ-ыг худалдан авсаны үр дүнд НБ-ын нэг хүнд ногдох орлого нь буцалтгүй тусламжийг хуваарилахдаа засгийн газраас тогтоосон босго шалгуураас илүү болж өссөн.
- ҮЖ277. 20Х3 оны 7 дугаар сарын 01-нд үндэсний засгийн газар нь НБ-ын өмнө авсан буцалтгүй тусламжийн тодорхой хэсэг (100 ТН)-ийг буцаан төлөхийг тус НБ-аас шаардсан. НБ нь 20Х3 оны 7 дугаар сарын 01-нд 100 ТН-ийн өр төлбөр ба зардлыг хүлээн зөвшөөрсөн.

### **Худалдан авалттай холбоотой тодруулгын шаардлагууд**

*УСНББОУС 40-ийн 119-125-р параграфт заасан тодруулгын шаардлагуудыг дагаж мөрдсөний үр дагаврыг үлгэрчлэн харуулах*

- ҮЖ278. Худалдан авалттай холбоотой тодруулгын зарим шаардлагуудыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан; энэ нь бодит ажил гүйлгээнд үндэслээгүй болно. Энэ жишээнд НБ нь өөрийн бүс нутагт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий улсын секторын байгууллага, харин ЗБ нь хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгж гэж үзсэн. Үлгэрчлэн тусгасан тодруулгын тусгай шаардлагуудад харгалзах тэдгээр тодруулгыг энэхүү жишээнд хүснэгтэн хэлбэрээр харуулсан. Бодит хөлийн тэмдэглэл нь энгийн хүүрнэсэн хэлбэрээр үлгэрчлэн харуулж болох олон тодруулгыг илэрхийлж болох юм.

#### **Харгалзах параграф**

120(а)-(г)

20Х2 оны 6 дугаар сарын 30-нд НБ нь ЗБ-ын энгийн хувьцааны 75 хувийг худалдан авч, түүний хяналтыг олж авсан. Энэхүү нэгдлийн эдийн засгийн мөн чанарын шинжилгээ нь уг ажил гүйлгээ худалдан авалт гэдгийг баталгаажуулж байна. ЗБ нь эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэгч юм. Уг худалдан авалтын үр дүнд НБ нь өөрийн иргэддээ үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулна гэж хүлээж байна. Мөн цар хүрээний хэмнэлтээр дамжуулан өртөг зардлыг бууруулахаар хүлээж байгаа юм.

120(д)

Худалдан авалтаас үүссэн 2,500 ТН-ийн гүүдвил нь НБ ба ЗБ-ын үйл ажиллагааг нэгтгэснээр хүлээгдэж буй өргөжилтийн хэмнэлт болон цар хүрээний хэмнэлтээс үндсэндээ бүрдэж байна.

120(м)

Хүлээн зөвшөөрсөн гүүдвил нь орлогын албан татварын зорилгоор хасагдах зардал болохооргүй байна. ЗБ-ын хувьд төлсөн төлбөр, уг худалдан авалтын өдрөөр хүлээн зөвшөөрсөн тухайн худалдан

УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

авсан хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн дүн, түүнчлэн ЗБ дахь хяналтын бус хувь оролцооны тэрхүү худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнийг дараах хүснэгтэнд нэгтгэн харуулав.

**20X2 оны 6 дугаар сарын 30**

	<b>Төлбөр</b>	<b>ТН</b>
120(е)(i)	Мөнгө	11,000
120(е)(iii), 120(ж)(i)	Болзошгүй төлбөрийн гэрээ	1,000
120(е)	<b>Шилжүүлсэн төлбөрийн дүн</b>	<u>12,000</u>
120(о)	<b>Худалдан авалттай холбоотой зардал</b> (НБ-ын 20X2 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан дахь борлуулалт, ерөнхий ба удирдлагын зардалд тусган оруулсан)	1,250
120(к)	<b>Худалдан авсан тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн хүлээн зөвшөөрсөн дүн</b>	
	Санхүүгийн хөрөнгө	3,500
	Бараа материал	1,000
	Үндсэн хөрөнгө	10,000
	Тодорхойлогдох биет бус хөрөнгө	3,300
	Санхүүгийн өр төлбөр	(4,000)
	Болзошгүй өр төлбөр	<u>(1,000)</u>
	Тодорхойлогдох цэвэр хөрөнгийн дүн	12,800
120(с)(i)	<b>ЗБ дахь хяналтын бус хувь оролцоо</b>	(3,300)
	<b>Гүүдвил</b>	<u>2,500</u>
		<u>12,000</u>
120(е)(iii) 120(ж) 124(б)	НБ нь ЗБ-ын өмчилж байсан нэгтгээгүй өмчийн хөрөнгө оруулалт болох ХБ-ын орлогын 5 хувийг уг ЗБ-ын хуучин эздэд төлөхөөр энэхүү болзошгүй төлбөрийн гэрээнд заасан. 20X3 оны хувьд ХБ-ын орлого нь 7,500 ТН-ээс давах бөгөөд төлөх дүн нь хамгийн ихдээ 2,500 ТН (дискаунтчилаагүй) байна. Болзошгүй төлбөрийн гэрээний дагуу төлөхийг НБ-аас шаардаж болох ирээдүйн бүх төлбөрүүдийн дикаунтчилаагүй боломжит дүн нь 0 ТН-ээс 2,500 ТН-ийн хооронд байна. Болзошгүй төлбөрийн гэрээний 1,000 ТН-ийн бодит үнэ цэнийг орлогын хандлага ашиглан тооцоолсон. Дискаунтын хувь нь 20-25 хувь, ХБ-ын магадлалаар тохируулсан, төсөөлсөн орлого нь 10,000 ТН- 20,000 ТН байна гэсэн гол таамаглалуудыг хийсэн гэж үзье. 20X2 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар уг болзошгүй төлбөрийн хэлцлийн хувьд хүлээн	

## УЛСЫН СЕКТОРЫН НЭГДЭЛ

- зөвшөөрсөн дүн ч байгаагүй, мөн тэрхүү тооцооллыг хийхэд ашигласан үр дүнгийн муж болон таамаглалууд ч өөрчлөгдөөгүй.
- 120(и) Олж эзэмшсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 2,375 ТН-ийн бодит үнэ цэнэ бүхий авлагыг тусгасан байна. Уг гэрээний дагуу авах авлагын нийт дүн нь 3,100 ТН бөгөөд үүнээс 450 ТН-ийг найдваргүй авлага болно гэж үзэж байна.
- 124(а) Тухайн олж эзэмшсэн, тодорхойлогдох биет бус хөрөнгийн 3,300 ТН-ийн бодит үнэ цэнэ нь нөхцөлт дүн бөгөөд эдгээр хөрөнгийн эцсийн үнэлгээг авахаар хүлээж байна.
- 120(л),  
124(в),  
УСНББОУС  
19-ийн 97,  
98 Сүүлийн 3 жилийн хугацаанд ЗБ-ын борлуулсан бүтээгдэхүүнд хүлээгдэж буй баталгаат засварын зардлын нэхэмжлэлийн хувьд 1,000 ТН-ийн болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. Бид энэ зардлын ихэнх хэсэг нь 20Х3 онд гаргах бөгөөд 20Х4 оны эцэс гэхэд бүх зардал гарсан байх болно гэж хүлээж байна. Баталгаат засварын гэрээний дагуу төлөхийг НБ-аас шаардаж болох ирээдүйн бүх төлбөрүүдийн дискаунтчилаагүй боломжит дүнг 500ТН - 1,500ТН-ийн хооронд байна гэж тооцоолсон. Уг өр төлбөрийн хувьд хүлээн зөвшөөрсөн дүн, үр дүнгийн муж буюу тэрхүү тооцооллыг хийхэд ашигласан таамаглалуудад 20Х2 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 20Х2 оны 6 дугаар сарын 30-наас хойш ямар нэг өөрчлөлт ороогүй.
- 120(с) Биржид бүртгэлтэй аж ахуйн нэгж болох ЗБ дахь хяналтын бус хувь оролцооны бодит үнэ цэнийг уг худалдан авалтын өдөр тэрхүү ЗБ-ын энгийн хувьцааны зах зээлийн хаалтын үнийг ашиглан хэмжсэн.
- 120(у)(i) 20Х2 оны 6-р сарын 30-ны өдрөөс хойш ЗБ-ын хувь нэмрээ оруулсан бөгөөд нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайланд тусгасан орлого нь 4,090 ТН байна. Мөн энэ хугацаанд ЗБ нь 1,710 ТН-ийн ашиг олж, хувь нэмрээ оруулсан.
- 120(у)(ii) Хэрэв ЗБ-ыг 20Х2 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш нэгтгэсэн бол нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайланд 27,670 ТН-ийн орлого, 12,870 ТН-ийн ашиг тусгах байсан.

Худалдан авалттай холбоотой тодруулгыг авч үзэх үедээ, байгууллага нь УСНББОУС 1-д заасан материаллаг байдлын хэлэлцүүлгийг харгалзах нь ач холбогдолтой байж болох юм.

### **СТОУС 3-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ**

УСНББОУС 40 дэх худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг СТОУС 3-аас (2004 онд гаргасан, үүнд 2015 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүд хамаарна) үндсэндээ бэлтгэсэн болно. УСНББОУС 40 ба СТОУС 3-ын эдгээр шаардлагуудын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- СТОУС 3 нь нэгтгэгчийг тодорхойлох заавар удирдамжийг агуулсан байдаг. Улсын секторын нэгдлийг нийлүүлэлт эсвэл худалдан авалт гэж ангилах үедээ үүнийг УСНББОУС 40-д харгалзан үздэг.
- УСНББОУС 40 нь улсын секторын тусгай ажил гүйлгээнүүд, тухайлбал татварын чөлөөлтийн талаархи нэмэлт заавар удирдамжийг агуулсан байдаг.
- УСНББОУС 40 нь зарим тохиолдолд СТОУС 3-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь “улсын секторын нэгдэл”, “үйл ажиллагаа”, “худалдан авсан үйл ажиллагаа” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. СТОУС 3 дахь адилтгах нэр томъёо нь “бизнесийн нэгдэл”, “бизнес”, “нэгдэгч” юм.



ЭНЭ ХУУДСЫГ ЗОРИУД ХООСОН ҮЛДЭЭВ

# **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ТАНИЛЦУУЛГА**

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ) нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартууд (УСНББОУС-ууд) гэж нэрлэгдэх, улсын секторын байгууллагуудад зориулсан нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг боловсруулдаг. Улс орнуудын хооронд тууштай ба зэрэгцүүлэгдэх санхүүгийн мэдээлэлтэй болсноор мэдэгдэхүйц үр өгөөжтэй гэдгийг УСНББОУСЗ нь хүлээн зөвшөөрдөг бөгөөд эдгээр үр өгөөжийг хэрэгжүүлэх боломжтой болоход УСНББОУС-ууд гол үүрэг гүйцэтгэнэ гэж найддаг. УСНББОУСЗ нь өөрийн Саналын Төслүүд ба Зөвлөлдөх Баримт Бичгүүдэд тусгасан саналуудад засгийн газрууд болон үндэсний стандарт тогтоогч нар санал шүүмж өгөх замаар Стандартын хөгжилд оролцохыг хүчтэй дэмждэг.

УСНББОУСЗ нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн болон аккруэл суурьт санхүүгийн тайлагналыг зохицуулах УСНББОУС-уудыг гаргадаг.

Засгийн газрууд нь УСНББОУС-уудыг дагаж мөрдсөнөөр дэлхий даяарх улсын секторын байгууллагуудын тайлагнаж буй санхүүгийн мэдээллийн чанар ба зэрэгцүүлэгдэх байдлын аль аль нь сайжрах юм. Өөрсдийн улс оронд нягтлан бодох бүртгэлийн стандартууд ба санхүүгийн тайлагналын заавруудыг боловсруулан гаргах засгийн газруудын болон үндэсний стандарт тогтоогчдын эрхийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. Энэхүү Стандарт нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурьт санхүүгийн тайлагналын тууштай ба зэрэгцүүлэгдэх байдлыг сайжруулах чухал алхам гэж гэж УСНББОУСЗ үздэг бөгөөд энэ Стандартыг дагаж мөрдөхийг дэмждэг. Санхүүгийн тайлан нь энэхүү УСНББОУС-ын Нэгдүгээр хэсэгт заасан бүх шаардлагуудтай нийцсэн зөвхөн тийм тохиолдолд түүнийг энэ УСНББОУС-тай нийцсэн гэж тодорхойлох хэрэгтэй.

Засгийн газрууд нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт шилжих ба нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг хэрэглэж буй байгууллагууд мөрдөхөд зориулан бэлтгэсэн УСНББОУС-уудтай өөрийн үндэсний шаардлагуудыг уялдуулахыг УСНББОУСЗ дэмждэг. Ирээдүйн тодорхой хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг мөрдөх санаа зорилго бүхий байгууллагууд нь УСНББОУСЗ-ийн бусад хэвлэл материалыг, тухайлбал Сургалтын материал 14, *Нягтлан Бодох Бүртгэлийн Аккруэл Суурьт Шилжилт: Засгийн Газрууд болон Засгийн Газрын Байгууллагуудад Зориулсан Удирдамж*-ийг ач холбогдолтой гэж үзэж болох юм.

# УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ: НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

## Стандартын бүтэц

Энэ Стандарт нь хоёр хэсгээс бүрдэнэ:

- Нэгдүгээр хэсгийг заавал дагаж мөрдөх ёстой. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу нийтлэг зорилготой санхүүгийн тайлан бэлтгэж буй бүх байгууллагуудын дагаж мөрдөх шаардлагуудыг тогтоодог. Мөн энэ нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг тодорхойлж, санхүүгийн тайлан болон түүний дэмжих тэмдэглэл дэх мэдээллийн тодруулгад тавигдах шаардлагуудыг тогтоох бөгөөд тайлагналын олон тооны тусгай асуудлуудыг зохицуулдаг. Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, “*Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал*”-ын дагуу тайлагнах шаардлагатай бүх байгууллагууд нь Стандартын энэ хэсэгт заасан шаардлагуудыг дагаж мөрдөх ёстой.
- Энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.1-ээс 1.8-р дэд хэсгүүдийг 2003 онд гаргасан. Нэгдүгээр хэсгийн 1.9-р дэд хэсэг, “Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга”-ийг 2006 онд боловсруулан гаргасан. 1.9-р дэд хэсгийг гаргасны үр дүнд Нэгдүгээр хэсгийн 1.3.4(в), 1.3.7, 1.3.9(в) параграфууд болон Хавсралт 1-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Нэгдүгээр хэсгийн 1.10-р дэд хэсэг, “Гадаад тусламж хүлээн авагчид”-ыг 2007 онд гаргасан. 1.10-р дэд хэсгийг гаргасны үр дүнд Нэгдүгээр хэсгийн Хавсралт 1 болон 1.3.18-р параграфт 2007 онд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- Хоёрдугаар хэсгийг заавал дагаж мөрдөх албагүй. Энэ нь өөрийн санхүүгийн хариуцлага болон санхүүгийн тайлангийн ил тод, ойлгомжтой байдлыг сайжруулахын тулд байгууллага мөрдөхийг сайшаан дэмжсэн нягтлан бодох бүртгэлийн нэмэлт бодлого, тодруулгыг тогтоосон. Түүнчлэн, зарим мэдээллийг толилуулах хувилбар аргуудын талаархи тайлбарыг энд тусган оруулсан.
- 2.1-р дэд хэсгийн 2.1.1-ээс 2.1.59-р параграфууд, 2.2-р дэд хэсэг, Хавсралт 2, 3, 4, 5-ыг 2003 онд гаргасан. Төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн талаархи зарим тодруулгыг дэмжихийн тулд 2.1.37-оос 2.1.40-р параграфуудыг 2006 онд Хоёрдугаар хэсэгт нэмж оруулсан бөгөөд үүний үр дүнд 2.1.36-р параграф болон Хавсралт 2-ыг хянан засварласан. Гадаад тусламжийн талаархи зарим тодруулгыг дэмжихийн тулд 2.1.64-ээс 2.1.93-р параграфуудыг 2007 онд Хоёрдугаар хэсэгт нэмж оруулсан бөгөөд үүний үр дүнд 2.1.25, 2.1.30-р параграфууд болон Хавсралт 2-ыг хянан засварласан.

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

### АГУУЛГА

	Танилцуулга	
	Стандартын бүтэц	
	<b>Нэгдүгээр хэсэг: Шаардлагууд</b>	
	Зорилт	
		Параграф
1.1	<b>Шаардлагуудын цар хүрээ</b>	1.1.1–1.1.7
1.2	<b>Мөнгөн суурь</b>	1.2.1–1.2.9
	Тодорхойлолт	1.2.1–1.2.9
	Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь	1.2.2
	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	1.2.3–1.2.5
	Тайлагнагч байгууллагын хянаж буй мөнгөн хөрөнгө	1.2.6–1.2.9
1.3	<b>Толилуулга ба тодруулгын шаардлагууд</b>	1.3.1–1.3.38
	Тодорхойлолт	1.3.1–1.3.3
	Санхүүгийн тайлан	1.3.4–1.3.11
	Мөнгөн орлого, зарлагын тайланд толилуулах мэдээлэл	1.3.12–1.3.29
	Ангилал	1.3.17
	Мөрийн зүйлс, гарчиг, дэд дүн	1.3.18
	Цэвэр дүнгээр тайлагнах	1.3.19–1.3.23
	Байгууллагын өмнөөс гуравдагч талын хийсэн төлбөр	1.3.24–1.3.29
	Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тайлбар тэмдэглэл	1.3.30–1.3.38
	Тэмдэглэлийн бүтэц	1.3.30–1.3.31
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт ба тодруулга	1.3.32–1.3.38
1.4	<b>Ерөнхий асуудлууд</b>	1.4.1–1.4.25
	Тайлант үе	1.4.1–1.4.3
	Цаг хугацаандаа байх	1.4.4
	Зөвшөөрсөн өдөр	1.4.5–1.4.6
	Байгууллагын тухай мэдээлэл	1.4.7–1.4.8
	Мөнгөний үлдэгдэлд болон зээл авахад тавигдах хязгаарлалт	1.4.9–1.4.12
	Толилуулгын тууштай байдал	1.4.13–1.4.15
	Зэрэгцүүлэгдэх мэдээлэл	1.4.16–1.4.20
	Санхүүгийн тайлангийн ялган тодорхойлолт	1.4.21–1.4.25
1.5	<b>Алдааны засварлалт</b>	1.5.1–1.5.5
1.6	<b>Нэгтгэсэн санхүүгийн тайлан</b>	1.6.1–1.6.21
	Тодорхойлолт	1.6.1–1.6.4
	Эдийн засгийн нэгдмэл байгууллага	1.6.2–1.6.4
	Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн цар хүрээ	1.6.5–1.6.15
	Нэгтгэлийн горим	1.6.16–1.6.19
	Нэгтгэлийн тодруулга	1.6.20
	Шилжилтийн нөхцлүүд	1.6.21

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРЬТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

1.7	<b>Гадаад валют</b>	1.7.1–1.7.8
	Тодорхойлолт	1.7.1
	Гадаад валютаарх мөнгөн орлого, зарлага, үлдэгдлийн бүртгэлийн арга	1.7.2–1.7.8
1.8	<b>Нэгдүгээр хэсгийн 1.1-ээс 1.7-р дэд хэсгүүдийн хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилтийн нөхцлүүд</b>	1.8.1–1.8.3
	Хүчин төгөлдөр болох хугацаа	1.8.1
	Шилжилтийн нөхцлүүд – Нэгтгэсэн санхүүгийн тайлан	1.8.2–1.8.3
1.9	<b>Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга</b>	1.9.1–1.9.48
	Тодорхойлолт	1.9.1–1.9.7
	Батлагдсан төсөв	1.9.2–1.9.4
	Анхны болон тодотгосон төсөв	1.9.5–1.9.6
	Гүйцэтгэлийн дүн	1.9.7
	Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлсэн толилуулга	1.9.8–1.9.32
	Цар хүрээ	1.9.9–1.9.10
	Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт	1.9.11–1.9.16
	Толилуулга	1.9.17–1.9.19
	Нэгтгэлийн түвшин	1.9.20–1.9.22
	Анхны төсвөөс тодотгосон төсөв болгох өөрчлөлт	1.9.23–1.9.24
	Зэрэгцүүлэгдэх суурь	1.9.25–1.9.30
	Олон жилийн төсөв	1.9.31–1.9.32
	Төсвийн суурь, хугацаа, цар хүрээний тэмдэглэл тодруулга	1.9.33–1.9.40
	Зэрэгцүүлэгдэх сууриар тусгасан гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайлан дахь гүйцэтгэлийн дүнгийн хоорондох тохируулга	1.9.41–1.9.46
	Нэгдүгээр хэсгийн 1.9-р дэд хэсгийн хүчин төгөлдөр болох хугацаа	1.9.47–1.9.48
1.10	<b>Гадаад тусламж хүлээн авагчид</b>	1.10.1–1.10.34
	Тодорхойлолт	1.10.1–1.10.7
	Гадаад тусламж	1.10.3–1.10.4
	Албан ёсны нөөц	1.10.5
	Гадаад тусламжийн хэлэлцээр	1.10.6–1.10.7
	Хүлээн авсан гадаад тусламж	1.10.8–1.10.17
	Зарцуулаагүй гадаад тусламж	1.10.18–1.10.20
	Бараа, үйлчилгээний хүлээн авалт	1.10.21–1.10.22
	Дахин хуваарь хийсэн эсвэл хүчингүй болгосон өрийн тодруулга	1.10.23–1.10.24
	Чухал нөхцөл ба болзлын үл биелүүлэлтийн талаархи тодруулга	1.10.25–1.10.27
	1.10-р дэд хэсгийн хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилтийн нөхцлүүд	1.10.28–1.10.34
	Хавсралт 1: Энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн шаардлагуудын үлгэрчилсэн жишээ	

	<b>Хоёрдугаар хэсэг: Сайшаан дэмжсэн нэмэлт тодруулга</b>	
2.1	<b>Сайшаан дэмжсэн нэмэлт тодруулга</b>	<b>2.1.1–2.1.63</b>
	Тодорхойлолт	2.1.1–2.1.2
	Ирээдүйн эдийн засгийн үр буюу үйлчилгээний чадавхи	2.1.2
	Тасралтгүй байх суурь	2.1.3–2.1.5
	Онцгой шинжтэй зүйлс	2.1.6–2.1.14
	Ердийн үйл ажиллагаанаас эрс ялгаатай	2.1.8
	Ойрын ирээдүйд дахин давтагдахаар хүлээгдээгүй	2.1.9
	Тухайн байгууллагын хяналт буюу нөлөөллөөс ангид	2.1.10
	Онцгой шинжтэй зүйлсийг тогтоох	2.1.11–2.1.14
	Туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээ	2.1.15–2.1.22
	Орлогын цуглуулалт	2.1.18–2.1.20
	“Дамжуулах” мөнгөн гүйлгээ	2.1.21
	Шилжүүлгийн төлбөр	2.1.22
	Мөнгөн гүйлгээний гол ангиудын тодруулга	2.1.23–2.1.30
	Холбоотой талуудын тодруулга	2.1.31–2.1.32
	Хөрөнгө, өр төлбөр болон төсвийн зэрэгцүүлэлтийн тодруулга	2.1.33–2.1.40
	Төсвийн зэрэгцүүлэлт	2.1.36–2.1.40
	Нэгтгэсэн санхүүгийн тайлан	2.1.41–2.1.48
	Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны бусад нэгжүүдийн олж эзэмшилт ба данснаас хасалт	2.1.44–2.1.48
	Хамтарсан үйлдвэр	2.1.49–2.1.50
	Хэт инфляцитай эдийн засгийн үеийн санхүүгийн тайлагнал	2.1.51–2.1.63
	Санхүүгийн тайлангийн дахин илэрхийлэлт	2.1.53–2.1.58
	Зэрэгцүүлэгдэх мэдээлэл	2.1.59
	Нэгтгэсэн санхүүгийн тайлан	2.1.60–2.1.61
	Үнийн ерөнхий индексийн сонголт ба хэрэглээ	2.1.62–2.1.63
	Төрийн Бус Байгууллага (ТББ)-аас хүлээн авсан тусламж	2.1.64–2.1.65
	Гадаад тусламж хүлээн авагчид	2.1.66–2.1.93
2.2	<b>Нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурьт шилжихээр төлөвлөж буй засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагууд</b>	<b>2.2.1–2.2.5</b>
	Мөнгөн орлого, зарлагын тайлангийн толилуулга	2.2.1–2.2.2
	Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн цар хүрээ – Эдийн засгийн нэгдмэл байгууллагыг үл хамруулах	2.2.3–2.2.5
	Хавсралт 2: Энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн зарим тодруулгын үлгэрчилсэн жишээ	

Хавсралт 3: УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-  
гаар шаардсан загвараар бэлтгэсэн Мөнгөн орлого,  
зарлагын тайлангийн толилуулга

Хавсралт 4: Санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд

Хавсралт 5: Санхүүгийн тайлагналын зорилгоор өөр  
байгууллагад хяналт тогтоох

---

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ШААРДЛАГУУД

*Энэ Стандартын Нэгдүгээр хэсэгт нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу тайлагналын шаардлагуудыг заасан.*

*Тод хараар, ташуу хэлбэрээр бичсэн стандартуудыг энэ Стандартад энгийн хэлбэрээр бичсэн тайлбар параграфууд болон “Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил”-ын хамт уншвал зохино. Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартыг материаллаг бус зүйлсэд мөрдөх санаа зорилгогүй болно.*

### Зорилт

Энэ Стандартын зорилго нь нийтлэг зорилготой санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу толилуулах арга хэлбэрийг тодорхойлоход оршино.

Байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдлийн талаархи мэдээлэл нь хариуцлагын зорилгын хувьд зайлшгүй шаардлагатай бөгөөд ирээдүйд зохих мөнгө бий болгох тухайн байгууллагын чадвар, түүнчлэн мөнгөний магадлалт эх үүсвэр ба ашиглалтын талаархи үнэлгээнд ач холбогдолтой орц өгөгдлөөр хангадаг. Мөнгөн нөөцийн хуваарилалт ба байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлын талаархи шийдвэрийг гаргаж, үнэлэхийн тулд хэрэглэгчид нь мөнгөн орлого, мөнгөн зарлагын цаг хугацаа болон магадлалт байдлын хувьд ойлголттой байх шаардлагатай юм.

Энэ Стандартын шаардлагууд болон сайшаан дэмжсэн зүйлсийг даган мөрдөх нь тухайн байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдлийн талаархи дэлгэрэнгүй ба ил тод санхүүгийн тайлагналыг бэхжүүлэн сайжруулах юм. Энэ нь тухайн байгууллагын өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайлантай болон нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг мөрддөг бусад байгууллагуудын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэгдэх байдлыг мөн сайжруулна.

### 1.1 Шаардлагуудын цар хүрээ

1.1.1 ***Энэ Стандартад тодорхойлсон нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь өөрийн нийтлэг зорилготой жилийн санхүүгийн тайлангийн толилуулгад энэ Стандартын Нэгдүгээр хэсэгт заасан шаардлагуудыг мөрдөх хэрэгтэй.***

1.1.2 Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь өөрсдийн мэдээллийн тусгай хэрэгцээ шаардлагыг хангахын тулд санхүүгийн тайлан бэлтгэлтийг түүнд тохируулан нийцүүлэхийг шаардах чадвар, боломжгүй тийм хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахад зориулагдсан санхүүгийн тайлан юм.



Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь татвар төлөгчид, төлбөр хураамж төлөгчид, хууль тогтоох байгууллагын гишүүд, зээлдүүлэгчид, бэлтгэн нийлүүлэгчид, хэвлэл мэдээллийн байгууллага болон ажиллагчид юм. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь жилийн тайлан илтгэл гэх мэт нийтийн зориулалттай бусад баримт бичгийн бүрэлдэхүүнд оруулан эсвэл тусад нь толилуулдаг санхүүгийн тайланг агуулсан байна.

- 1.1.3 Энэхүү Стандартыг бие даасан байгууллагын нийтлэг зорилготой санхүүгийн тайлан болон нийт засгийн газар гэх мэт эдийн засгийн нэгдмэл байгууллагын нийтлэг зорилготой нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгэн адил мөрдөнө. Тайлагнагч байгууллагын хянаж буй мөнгийг тусган хүлээн зөвшөөрөх мөнгөн орлого, зарлагын тайлангийн бэлтгэлт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга, тайлбар тэмдэглэлийн хувьд энэ Стандарт шаардлагатай юм. Мөн энэ нь тухайн тайлагнагч байгууллагын өмнөөс гуравдагч талын барагдуулсан дүнг мөнгөн орлого, зарлагын тайланд тодруулахыг шаарддаг.
- 1.1.4 ***Энэхүү Стандартын Нэгдүгээр хэсгийн шаардлагуудтай нийцсэн санхүүгийн тайлан бүхий байгууллага нь энэ тухай тодруулга хийх хэрэгтэй. Санхүүгийн тайлан нь энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн бүх шаардлагуудтай нийцсэн биш л бол түүнийг тус Стандарттай нийцсэн гэж илэрхийлж болохгүй.***
- 1.1.5 ***Энэ Стандартыг Улсын Үйлдвэрийн Газраас бусад, улсын секторын бүх байгууллагууд мөрдөнө.***
- 1.1.6 Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг бүх байгууллагын нийтлэг зорилготой санхүүгийн тайланд мөрдөхөөр Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ыг төлөвлөн зохиомжилсон гэдгийг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан *Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Оршил*-д тайлбарласан байдаг. Улсын Үйлдвэрийн Газар (УҮГ)-ыг доорх 1.2.1-р параграфт тодорхойлсон. Эдгээр нь ашгийн төлөө байгууллагууд юм. Иймээс Улсын Үйлдвэрийн Газрууд нь СТОУС болон Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС)-ыг дагаж мөрдөх шаардлагатай юм.
- 1.1.7 Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (НББОУСХ)-г орлуулан өөрчлөхийн тулд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-ийг 2001 онд байгуулсан. НББОУСХ-ноос гаргасан НББОУС-ууд нь тэдгээрт НББОУСЗ-өөс нэмэлт өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна.

## 1.2 Мөнгөн суурь

### Тодорхойлолт

1.2.1 *Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:*

**Мөнгө** нь бэлэн мөнгө, харилцах данс болон мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бүрдэнэ.

**Мөнгөн суурь** гэдэг нь ажил гүйлгээ ба бусад үйл явдлыг зөвхөн мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн үед хүлээн зөвшөөрдөг нягтлан бодох бүртгэлийн суурь юм.

**Мөнгөтэй адилтгах хөрөнгө** нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, хөрвөх чадвар өндөртэй хөрөнгө оруулалт юм.

**Мөнгөн гүйлгээ** нь мөнгөний орлогын болон зарлагын урсгал юм.

**Мөнгөн зарлага** нь мөнгөний зарлагын урсгал юм.

**Мөнгөөр орлого** нь мөнгөний орлогын урсгал юм.

**Мөнгөний хяналт** нь байгууллага өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд мөнгийг ашиглах эсвэл өөр бусад байдлаар мөнгөнөөс өгөөж хүртэх бөгөөд тэрхүү өгөөжид бусад талуудыг хандан нэвтрүүлэхгүй байх буюу хандан нэвтрэлтийг зохицуулж чадах тохиолдолд үүсдэг.

**Улсын үйлдвэрийн газар** гэдэг нь дараах бүх шинж чанар бүхий байгууллагыг хэлнэ:

- (а) **Өөрийн нэрээр гэрээ байгуулах бүрэн эрхтэй;**
- (б) **Бизнесийг эрхлэн явуулах санхүүгийн болон үйл ажиллагааны эрх олгогдсон;**
- (в) **Өөрийн бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа, үйлчилгээг бусдад ашигтайгаар эсвэл бүрэн өртгийг нөхөх дүнгээр борлуулдаг;**
- (г) **Тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа явуулахын тулд (холбоогүй талуудын ажил гүйлгээгээр бүтээгдэхүүнийг худалдан авахаас бусад тохиолдолд) Засгийн газрын байнгын санхүүжилтээс хамааралгүй байдаг; ба**
- (д) **Улсын секторын байгууллагын хяналтанд байдаг.**

### Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь

1.2.2 Байгууллага нь зөвхөн мөнгө (үүн дотроо, мөнгөтэй адилтгах хөрөнгө) хүлээн авсан эсвэл төлсөн үед нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь нь ажил гүйлгээ болон үйл явдлыг хүлээн зөвшөөрдөг. Мөнгөн суурийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан нь тухайн тайлант үеийн туршид бий болсон

мөнгөний эх үүсвэр, мөнгийг ашиглан зарцуулсан зорилго, тайлангийн өдрөөрх мөнгөний үлдэгдлийн талаархи мэдээллээр хэрэглэгчдийг хангадаг. Санхүүгийн тайлан дахь хэмжилтийн анхаарах зүйл нь мөнгөний үлдэгдлүүд ба тэдгээрийн өөрчлөлт юм. Санхүүгийн тайлангийн тэмдэглэл нь өглөг, зээл гэх мэт өр төлбөр болон авлага, хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгө гэх мэт мөнгөн бус зарим хөрөнгийн талаархи нэмэлт мэдээллээр хангаж болох юм.

### **Мөнгөтэй адилтгах хөрөнгө**

- 1.2.3 Хөрөнгө оруулалтын буюу бусад зорилго гэхээс илүүтэйгээр мөнгөний богино хугацааны хариуцлагаа биелүүлэх зорилгоор мөнгөтэй адилтгах хөрөнгийг эзэмшдэг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийн шалгуурыг хангахын тулд хөрөнгө оруулалт нь мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой бөгөөд үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй байх ёстой. Иймээс хөрөнгө оруулалт нь богино хугацаатай, тодруулбал; худалдан авч эзэмшсэнээс хойш 3 сар буюу түүнээс богино хугацаанд дуусгавар болох хугацаатай байх зөвхөн тийм тохиолдолд мөнгөтэй адилтгах хөрөнгийн шалгуурыг ихэвчлэн хангадаг. Мөн чанарын хувьд мөнгөтэй адилтгах хөрөнгө байхаас бусад тохиолдолд өмчийн хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй.
- 1.2.4 Банкны зээлийг ерөнхийдөө мөнгөний орлогын гүйлгээ үүсэхэд хүргэдэг гэж үздэг. Гэвч шаардлагаар шууд буцаан төлөгдөх банкны овердрафт нь зарим улс оронд тухайн байгууллагын мөнгөн хөрөнгийн удирдлагын салшгүй нэг хэсэг болдог. Энэ тохиолдолд банкны овердрафтыг мөнгөн хөрөнгийн бүрэлдэхүүнд оруулдаг. Банкны ийм хэлцлүүдийн онцлог шинж нь банкны дансны үлдэгдлийг эерэг дүнгээс сөрөг дүн болж байнга хэлбэлзэхэд хүргэдэг явдал юм.
- 1.2.5 Мөнгийг бүрдүүлж буй зүйлс нь тухайн байгууллагын хянаж буй мөнгөний нэмэгдэлт эсвэл бууралт гэхээсээ илүүтэйгээр түүний мөнгөн хөрөнгийн удирдлагын бүрэлдэхүүн хэсэг болдог тул тэдгээр зүйлсийн хоорондох хөдөлгөөнийг мөнгөн гүйлгээнд оруулахгүй. Өөрийн илүүдэл мөнгөөр мөнгөтэй адилтгах хөрөнгөнд хийх хөрөнгө оруулалт нь мөнгөн хөрөнгийн удирдлагад хамаарна.

### **Тайлагнагч байгууллагын хянаж буй мөнгөн хөрөнгө**

- 1.2.6 Байгууллага нь өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд мөнгийг ашиглах эсвэл өөр бусад байдлаар мөнгөнөөс өгөөж хүртэх бөгөөд тэрхүү өгөөжид бусад талуудыг хандан нэвтрүүлэхгүй байх буюу хандан нэвтрэлтийг зохицуулж чадах тохиолдолд мөнгийг хянадаг. Байгууллага өөрийн цуглуулсан эсвэл түүнд хуваарилсан буюу олгосон мөнгийг үйл ажиллагааны зорилтуудыг санхүүжүүлэх, капитал хөрөнгийг худалдан авах, өрөө буцаан төлөхөд ашиглаж чадах тохиолдолд тухайн байгууллага нь мөнгийг хянадаг.
- 1.2.7 Байгууллагын банкин дахь харилцах дансанд байршуулсан мөнгийг тухайн байгууллага хянадаг. Зарим тохиолдолд засгийн газрын байгууллага нь:

- (а) Өөрийн засгийн газрын (болон бусад байгууллагын) өмнөөс цуглуулсан мөнгийг нэгтгэсэн орлогын буюу засгийн газрын бусад ерөнхий дансанд шилжүүлэхээс өмнө, өөрийн банкин дахь харилцах дансанд байршуулдаг; ба
- (б) Өөрийн засгийн газрын өмнөөс гуравдагч талд шилжүүлэх ёстой мөнгийг тухайн зөвшөөрөгдсөн хүлээн авагчид шилжүүлэхээс өмнө, өөрийн банкин дахь харилцах дансанд эхлээд байршуулдаг.

Эдгээр тохиолдолд байгууллага нь мөнгийг нэгтгэсэн орлогын буюу засгийн газрын хяналтанд буй бусад банкны дансанд эсвэл гуравдагч талд шилжүүлэхээс өмнө, өөрийн банкны харилцах дансанд байлгах зөвхөн тэрхүү хугацаанд хянадаг. Тайлангийн өдрөөр тухайн байгууллага эзэмшиж байгаа боловч ашиглах боломжгүй буюу гаднын хязгаарлалт тавигдсан мөнгөний үлдэгдлийн талаар тодруулга хийхийг 1.4.9-р параграфтаар шаардсан байдаг. Бусад байгууллагуудын өмнөөс тухайн байгууллагын туслалцаа үзүүлсэн мөнгөн гүйлгээний бүртгэлийн аргын талаархи нэмэлт заавар удирдамжийг энэ Стандартын Хоёрдугаар хэсгийн 2.1.15-2.1.22-р параграфуудад тусгасан.

1.2.8 Зарим улс оронд, “нэг данс”-ны суурь гэж ихэвчлэн нэрлэдэг, төвлөрсөн төрийн сангийн чиг үүргээр дамжуулан засгийн газар нь өөрийн бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын зарлагыг удирддаг. Ийм зохицуулалтын дагуу бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагууд нь өөрийн банкны дансыг хянадаггүй. Харин засгийн газрын “нэг” данс буюу хэд хэдэн дансаар дамжуулан төв байгууллага нь засгийн газрын мөнгийг удирддаг. Уг төв байгууллага нь зохих зөвшөөрөл ба баримтжуулалтын дагуу тэдгээр бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын өмнөөс төлбөрийг хийдэг. Иймээс бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагууд нь түүнд хуваарилагдсан буюу өөр бусад байдлаар зарцуулах зөвшөөрөл олгогдсон мөнгийг хянадаггүй. Ийм тохиолдолд 1.3.24(а) параграфын шаардлагуудын дагуу бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагууд нь тухайн гаргасан зарлагыг мөнгөн орлого, зарлагын тайлан дахь “төрийн сангийн данс” гэж нэрлэгдэх тусдаа баганад (буюу үүнтэй адилаар нэрлэсэн баганад) тайлагнана.

1.2.9 Зарим тохиолдолд банкны данс (дансууд)-ыг хянадаг байгууллага нь үйл ажиллагааны бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын өмнөөс төлбөрийг тус данснаас хийж, төвлөрсөн төрийн сангийн чиг үүргийг гүйцэтгэдэг. Энэ тохиолдолд тэдгээр банкны дансанд орсон шилжүүлэг ба уг данснаас хийгдсэн төлбөр нь үйл ажиллагааны бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын өмнөөс уг төв байгууллагын гүйцэтгэж буй мөнгөн орлого, зарлагыг тусгадаг. Бусад байгууллагуудын өмнөөс тухайн байгууллагын гүйцэтгэж буй ажил гүйлгээнээс үүсдэг бөгөөд анхдагч санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг мөнгөн орлого, зарлагыг цэвэр дүнгээр тайлагнаж болно гэдгийг 1.3.13-р параграфт тусгайлан заасан. Тайлангийн өдрөөр тухайн байгууллага эзэмшиж байгаа боловч ашиглах боломжгүй буюу гаднын хязгаарлалт тавигдсан мөнгөний үлдэгдлийн талаар тодруулга хийхийг 1.4.9-р параграфтаар шаардсан байдаг.

### 1.3 Толилуулга ба тодруулгын шаардлагууд

#### Тодорхойлолт

- 1.3.1 *Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:*

**Нягтлан бодох бүртгэлийн бодлого** гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик юм.

**Материаллаг байдал** Тухайн зүйлийн орхигдуулалт буюу буруу илэрхийлэлт нь уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн шийдвэр эсвэл үнэлгээнд нөлөө үзүүлж чадахаар байвал түүнийг материаллаг гэж үзнэ. Материаллаг байдал нь тухайн нөхцөл байдлын хүрээнд шүүн тунгаасан уг орхигдуулалт буюу буруу илэрхийлэлтийн шинж төрөл ба хэмжээнээс хамаардаг.

**Тайлангийн өдөр** гэдэг нь тухайн санхүүгийн тайлангийн хамаарах тайлант үеийн сүүлчийн өдрийг хэлнэ.

**Эдийн засгийн нэгдмэл байгууллага** гэдэг нь хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй нэг буюу хэд хэд байгууллагуудаас бүрдэх байгууллагуудын группыг хэлнэ.

- 1.3.2 Маш олон тооны ажил гүйлгээг тэдгээрийн шинж төрөл эсвэл чиг үүргийн дагуу ангиудад нэгтгэн нийлүүлэх боловсруулалтын үр дүнд санхүүгийн тайланг бэлтгэдэг. Нэгтгэн нийлүүлэх ба ангилах боловсруулалтын эцсийн үе шат нь хураангуйлж, ангилсан мэдээний толилуулга бөгөөд энэ нь санхүүгийн тайланд эсвэл тэмдэглэлд тусгах мөрийн зүйлсийг бүрдүүлдэг. Хэрэв мөрийн зүйл нь дангаараа материаллаг биш бол түүнийг санхүүгийн тайланд эсвэл тэмдэглэлд тусгахдаа бусад мөрийн зүйлстэй нэгтгэн нийлүүлдэг. Санхүүгийн тайланд тусдаа толилуулах үндэслэл болохуйц хангалттай материаллаг биш зүйл нь тэмдэглэлд тусдаа толилуулахад хангалттай материаллаг байж болох юм.
- 1.3.3 Хэрэв үр дүнгийн мэдээлэл нь материаллаг бус бол Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын тодруулгын тусгай шаардлагуудыг биелүүлэх албагүй гэдгийг материаллаг байдлын зарчим илэрхийлдэг.

#### Санхүүгийн тайлан

- 1.3.4 ***Байгууллага нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан нийтлэг зорилготой санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулах хэрэгтэй:***

(a) ***Мөнгөн орлого, зарлагын тайлан. Үүнд:***

(i) ***Байгууллагын хянаж буй бүх мөнгөн орлого, зарлага болон мөнгөний үлдэгдлийг хүлээн зөвшөөрнө; ба***

- (ii) **Тухайн байгууллагын өмнөөс гуравдагч талын хийсэн төлбөрүүдийг энэ Стандартын 1.3.24-р параграфын дагуу тусад нь харуулна;**
  - (б) **Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тайлбар тэмдэглэл; болон**
  - (в) **Байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаг тохиолдолд энэ Стандартын 1.9.8-р параграфын дагуу тусдаа нэмэлт санхүүгийн тайлан эсвэл мөнгөн орлого, зарлагын тайланд төсвийн багана байдлаар харуулсан төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт.**
- 1.3.5 **Байгууллага нь энэ Стандартад тодорхойлсон буюу 1.3.4(а) болон 1.3.4(в) параграфт бусад байдлаар шаардсан нягтлан бодох бүртгэлийн мөнгөн сууриас өөр сууриар бэлтгэсэн мэдээллийг тодруулах сонголт хийсэн бол ийм мэдээллийг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулах хэрэгтэй.**
- 1.3.6 Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь мөнгөн орлого, зарлагын тайлан, түүнчлэн байгууллагын хянаж буй мөнгөн орлого, зарлага, мөнгөний үлдэгдлийн талаархи нэмэлт мэдээллийг тодруулах бусад тайлангууд болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тэмдэглэлээс бүрдэнэ. Дээрх 1.3.4(а)(i) параграфын шаардлагуудын дагуу, байгууллагын хянаж буй зөвхөн мөнгөн орлого, зарлага болон мөнгөний үлдэгдлийг мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл бэлтгэж болох бусад тайланд ийм байдлаар хүлээн зөвшөөрнө. Дээрх 1.3.4(в) параграфын шаардлагуудын дагуу, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг нэмэлт санхүүгийн тайлан хэлбэрээр өөртөө агуулсан байж болно.
- 1.3.7 Тайлагнагч байгууллагын өмнөөс гуравдагч талын хийсэн зарим төлбөрүүдийг мөнгөн орлого, зарлагын тайланд тусгахыг энэ Стандартын 1.3.24-р параграфтаар шаардсан байдаг. Гуравдагч талын хийсэн төлбөр нь энэ Стандартын 1.2.1-р параграфт тодорхойлсон мөнгө, мөнгөн зарлага, мөнгөн орлогын тодорхойлолтыг хангахгүй бөгөөд тухайн тайлагнагч байгууллагын хянаж буй мөнгөн орлого, зарлагын адилаар тэдгээрийг мөнгөн орлого, зарлагын тайланд, эсвэл уг тайлагнагч байгууллагын бэлтгэж болох бусад тайланд толилуулахгүй. Санхүүгийн тайлан болон төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар зөвхөн бэлтгэсэн тохиолдолд байгууллага нь төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг мөнгөн орлого, зарлагын тайланд төсвийн нэмэлт багана байдлаар толилуулж болно гэж энэ Стандартын 1.9.17-р параграфт заасан. Санхүүгийн тайлан болон төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгээгүй тохиолдолд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тусдаа тайланг толилуулна.
- 1.3.8 Санхүүгийн тайлангийн тэмдэглэл нь тухайн санхүүгийн тайланд харуулсан дүнгүүдийн хүүрнэсэн тайлбар буюу илүү дэлгэрэнгүй задаргаа болон шинжилгээ, түүнчлэн нэмэлт мэдээллээс бүрддэг. Тэмдэглэл нь энэ Стандартаар тодруулахыг шаардсан ба сайшаан дэмжсэн мэдээллүүдээс

бүрдэх бөгөөд үнэн зөв толилуулгад хүрэхэд болон хариуцлагатай байдлыг сайжруулахад шаардлагатай гэж үзсэн бусад тодруулгыг агуулсан байж болно.

1.3.9 Дээрх 1.3.4-р параграфт заасанчлан, байгууллага нь мөнгөн орлого, зарлагын тайлангаас гадна бусад тайланг өөрийн нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусган оруулахыг энэ Стандартаар хориглодоггүй. Иймээс, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь тухайлбал, дараах зүйлсийг тайлагнах нэмэлт тайлангуудыг агуулсан байж болно:

- (а) Нэгтгэсэн орлогын сан гэх мэт мөнгө сангийн гол ангиллуудын хувьд мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдлийг тайлагнах;
- (б) Зээлийн эх үүсвэр ба ашиглан зарцуулалт, мөнгөн зарлагын шинж чанар ба төрлийн талаархи нэмэлт мэдээллээр хангах; эсвэл
- (в) Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг харуулах.

Дээрх 1.3.5-р параграфын шаардлагуудын дагуу, аливаа нэмэлт тайлан нь тухайн байгууллагын хянаж буй мөнгөн орлого, зарлага болон үлдэгдлийг зөвхөн тайлагнадаг.

1.3.10 Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг ашиглан тайлагнаж буй байгууллагууд нь мөнгөн суурьт нягтлан бодох бүртгэлийн дагуу хүлээн зөвшөөрдөггүй зүйлсийн талаархи мэдээллийг байнга цуглуулдаг. Цуглуулж болох мэдээллийн төрлийн жишээнд дараах зүйлсийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл хамаарна:

- (а) Авлага, өглөг, зээл ба бусад өр төлбөр, мөнгөн бус хөрөнгө, хуримтлагдсан орлого ба зардал;
- (б) Баталгаа ба болзошгүй өр төлбөр;
- (в) Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд ба үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилт.

1.3.11 Энэ Стандартын дагуу нийтлэг зорилготой санхүүгийн тайлангаа бэлтгэж буй байгууллагууд нь хэрэглэгчдэд тухайн мэдээлэл ач холбогдолтой байх магадлалтай тохиолдолд түүнийг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулж болно. Хийсэн тодруулгаа тодорхой тайлбарлах бөгөөд тодруулга нь шууд ойлгогдохуйц байвал зохино. Төсөвтэй хийсэн зэрэгцүүлэлтийг санхүүгийн тайланд тусгаагүй бол тэмдэглэл хэсэгт оруулж болно. Мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөрийн талаархи мэдээлэл, төсөвтэй хийсэн зэрэгцүүлэлтийг нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусган оруулахыг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт дэмжсэн.

### **Мөнгөн орлого, зарлагын тайланд толилуулах мэдээлэл**

1.3.12 ***Мөнгөн орлого, зарлагын тайланд тухайн тайлант үеийн дараах дүнгүүдийг толилуулах хэрэгтэй:***

- (а) ***Байгууллагын нийт мөнгөн орлого, үүнд: тухайн байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой ангиллын***

*суурийг ашиглан нийт мөнгөн орлогын дэд ангиллыг тусад нь харуулах;*

*(б) Байгууллагын нийт мөнгөн зарлага, үүнд: тухайн байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой ангиллын суурийг ашиглан нийт мөнгөн зарлагын дэд ангиллыг тусад нь харуулах;*

*(в) Байгууллагын мөнгөн хөрөнгийн эхний ба эцсийн үлдэгдэл.*

**1.3.13** *Нийт мөнгөн орлого ба нийт мөнгөн зарлага, түүнчлэн мөнгөн орлого, зарлагын дэд ангилал тус бүрийн мөнгөн орлого, зарлагыг нийт дүнгээр тайлагнах хэрэгтэй, харин дараах тохиолдолд мөнгөн орлого, зарлагыг цэвэр дүнгээр тайлагнаж болно:*

*(а) Бусад талуудын өмнөөс байгууллагын туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээнээс тэдгээр нь үүссэн бөгөөд мөнгөн орлого, зарлагын тайланд тэдгээрийг хүлээн зөвшөөрдөг; эсвэл*

*(б) Тэдгээр нь хурдан эргэлттэй, өндөр дүнтэй, дуусгавар болох богино хугацаатай зүйлсэд хамаардаг.*

**1.3.14** *Мөрийн зүйлс, гарчиг, дэд дүнгүүдийн толилуулга нь тухайн байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдлийг үнэн зөв толилуулахад шаардлагатай тохиолдолд тэдгээрийг мөнгөн орлого, зарлагын тайланд толилуулах хэрэгтэй.*

**1.3.15** Энэ Стандарт нь тухайн байгууллагын мөнгөний эхний ба эцсийн үлдэгдэл, тайлант үеийн турш дахь нийт мөнгөн орлого ба нийт мөнгөн зарлага, тэдгээрийн гол дэд ангиллуудыг харуулсан мөнгөн орлого, зарлагын тайлан толилуулахыг бүх байгууллагуудаас шаарддаг. Энэ нь байгууллагын мөнгөний үлдэгдлүүд болон тайлант үеийн туршид тэдгээрт гарсан өөрчлөлтийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг хэрэглэгчид хандан нэвтрэх боломжтой ба ойлгомжтой хэлбэрээр санхүүгийн тайланд тусгасан эсэхийг ханган магадалдаг.

**1.3.16** Байгууллагын мөнгөний үлдэгдэл, түүнчлэн мөнгө нь татвар, торгууль, хураамж, зээллэгээс үүссэн эсэх ба түүнийг үйл ажиллагааны зардал, капитал хөрөнгийн худалдан авалт эсвэл өрийн эргэлтээс гаргалтанд зориулан зарцуулсан эсэх гэх мэт асуудлуудын талаархи мэдээллийн тодруулга нь санхүүгийн тайлагналын ил тод ба хариуцлагатай байдлыг сайжруулна. Эдгээр тодруулгууд нь байгууллагын мөнгөний одоогийн нөөц, ирээдүйн мөнгөн орлогын гүйлгээний магадлалт эх үүсвэр болон тогтвортой байдлын талаар илүү их мэдээлэл бүхий шинжилгээ, үнэлгээ хийхэд мөн туслалцаа үзүүлдэг.

## **Ангилал**

**1.3.17** 1.3.12 ба 1.3.14-р параграфуудын дагуу толилуулах нийт мөнгөн орлого, зарлагын дэд ангиллууд (буюу ангиуд) нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал юм. Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурт санхүүгийн тайлагналын зорилт ба чанарын шинжүүдийн хүрээнд ийм шүүн тунгаалтыг



хийнэ. Санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг энэ Стандартын Хавсралт 4-д товчоолон харуулсан. Мөнгөн орлогыг тухайлбал, дараах зүйлсээс үүссэн гэдгээр тусдаа тодорхойлохын тулд нийт мөнгөн орлогыг ангилж болно. Үүнд: татвар буюу төсвийн хуваарилалт; буцалтгүй тусламж ба хандив; зээл; үндсэн хөрөнгийн данснаас хасалтын орлого; үйлчилгээ үзүүлэх ба худалдаа эрхлэх бусад байнгын үйл ажиллагаа. Мөнгөн зарлагыг тухайлбал, дараах зүйлстэй холбоотой гэдгээр тусдаа тодорхойлохын тулд нийт мөнгөн зарлагыг ангилж болно: үйлчилгээ үзүүлэх байнгын үйл ажиллагаа, үүн дотроо иргэд, бусад засгийн газар буюу байгууллагуудад олгох шилжүүлэг; өр бууруулах хөтөлбөр; үндсэн хөрөнгийн худалдан авалт; аливаа худалдааны үйл ажиллагаа. Толилуулгыг өөр хувилбараар бас хийх боломжтой юм. Жишээлбэл; нийт мөнгөн орлогыг тэдгээрийн эх үүсвэрийг харгалзсанаар ангилж болох ба мөнгөн зарлагыг түүний зарлагын шинж төрөл, тухайн байгууллагын хүрээн дэх чиг үүрэг эсвэл хөтөлбөрийн аль тохиромжтойг харгалзан дэд ангилал үүсгэж болно.

### **Мөрийн зүйлс, гарчиг, дэд дүн**

1.3.18 Дээрх 1.3.14-р параграфын шаардлагуудын дагуу, дэд ангилал тус бүрийн хүрээнд аль мөрийн зүйлс, гарчиг, дэд дүнг толилуулах хэрэгтэй эсэхийг тодорхойлоход харгалзах хүчин зүйлсэд дараах зүйлс хамаарна: энэ Стандартын бусад хэсгүүдийн шаардлагууд (жишээлбэл; тайлант үеийн туршид мөнгөөр хүлээн авсан нийт гадаад тусламжийг Мөнгөн орлого, зарлагын тайланд тусад нь тодруулахыг 1.10.8-р параграфтаар шаардсан байдаг); хэрэглэгчдэд зориулсан тодруулгын магадлалт материаллаг байдлын үнэлгээ; шаардлагатай тайлбар ба тодруулгыг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусгах хэмжээ. Байгууллага нь санхүүгийн тайлангийн тэмдэглэлд эсвэл тухайн санхүүгийн тайланд өөрт нь тусган оруулахыг уг байгууллагад сайшаан дэмждэг, мөнгөн гүйлгээний гол нэмэлт ангиудын талаархи тодруулгыг энэ Стандартын Хоёрдугаар хэсгийн 2.1.23-2.1.30-р параграфуудад заасан. Эдгээр тодруулга нь дээрх 1.3.12-р параграфын шаардлагуудыг бүх биш боловч олон тохиолдолд хангах магадлалтай юм.

### **Цэвэр дүнгээр тайлагнах**

1.3.19 Дээрх 1.3.13-р параграфт дурдсан нөхцлөөс бусад тохиолдолд мөнгөн орлого, зарлага болон үлдэгдлийг нийт дүнгээр тайлагнахыг энэ Стандартаар шаарддаг. Цэвэр дүнгээр тайлагнахыг зөвтгөн баталж болох тийм нөхцөл байдлуудыг доорх 1.3.20-1.3.21-р параграфт илүү дэлгэрэнгүй авч үзсэн.

1.3.20 Засгийн газрууд, засгийн газрын хэлтэс газрууд болон засгийн газрын бусад байгууллагууд нь ажил гүйлгээнд туслалцаа үзүүлэх буюу бусдын өмнөөс агентын үүргийг өөр бусад байдлаар гүйцэтгэж болох юм. Эдгээр туслалцаа үзүүлэх болон агентын ажил гүйлгээ нь бусад байгууллагын өмнөөс орлогыг цуглуулах, шалгуур хангасан үр шим хүртэгчдэд мөнгө санг шилжүүлэх, иргэдийн өмнөөс мөнгийг хадгалах зэрэг үйл ажиллагаанаас

бүрдэж болно. Ийм үйл ажиллагааны жишээнд дараах зүйлс хамаарч болох юм:

- (а) Засгийн газрын нэг түвшний өмнөөс засгийн газрын нөгөө түвшин нь татварыг цуглуулах, харин татварын орлого хуваах хэлцлийн нэг хэсэг байдлаар өөрийн хэрэгцээнд зориулж тухайн засгийн газрын цуглуулсан татвар үүнд хамаарахгүй;
- (б) Санхүүгийн байгууллагын зүгээс харилцах дансны хүлээн авалт ба буцаан олголт;
- (в) Үйлчлүүлэгчдийн өмнөөс хөрөнгө оруулалтын болон итгэмжлэлийн байгууллагын эзэмшиж буй мөнгөн сан;
- (г) Үл хөдлөх хөрөнгийн эздийн өмнөөс цуглуулж, тэдэнд төлдөг түрээс;
- (д) Засгийн газрын хэлтэс газраас хууль тогтоомж буюу засгийн газрын бусад бүрэн эрхийн дагуу гуравдагч талд хийсэн шилжүүлэг; ба
- (е) Засгийн газрын зарлагын удирдлагын зорилгоор “нэг данс”-ны суурийн дагуу төв байгууллагаас захиран зарцуулж буй мөнгө сан (1.2.8-р параграфт дурдсан).

1.3.21 Олон тохиолдолд, бусдын агент байдлаар туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээний хувьд байгууллагын хүлээн авсан мөнгийг тухайн мөнгөний эцсийн хүлээн авагчид зориулан итгэмжлэлийн дансанд эсвэл түүний банкны дансанд шууд байршуулдаг. Ийм тохиолдолд байгууллага нь туслалцаа үзүүлсэн уг ажил гүйлгээний хувьд хүлээн авсан мөнгийг хянахгүй бөгөөд тэдгээр мөнгөн гүйлгээ нь тус байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага болон мөнгөний үлдэгдлийн нэг хэсгийг бүрдүүлэхгүй. Харин өөр зарим тохиолдолд агентын үүрэг гүйцэтгэж буй байгууллагын хянадаг банкны дансанд тухайн хүлээн авсан мөнгийг байршуулах бөгөөд тэрхүү мөнгөн орлого ба шилжүүлгийг уг байгууллагын мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнана.

1.3.22 Зарим тохиолдолд, туслалцаа үзүүлэх ажил гүйлгээнээс үүссэн ба тайлагнагч байгууллагын банкны дансаар “дамжуулах” мөнгөн гүйлгээний дүн нь тухайн байгууллагын өөрийн ажил гүйлгээтэй харьцуулахад харьцангуй их дүнтэй байж болох бөгөөд тэрхүү дүнг эцсийн хүлээн авагчид шилжүүлэхээс өмнө зөвхөн богино хугацаанд хяналт тогтоож болох юм. Бусад мөнгөн гүйлгээний хувьд тухайлбал, дараах зүйлсийн урьдчилгаа төлбөр болон буцаан төлөлтийг хийхэд ийм тохиолдол бас үүсэж болно:

- (а) Хөрөнгө оруулалтын худалдан авалт болон борлуулалт; ба
- (б) Бусад богино хугацаат зээл, жишээлбэл; гурван сар буюу түүнээс богино дуусгавар болох хугацаатай зээл.

1.3.23 Эдгээр ажил гүйлгээг нийт дүнгээр хүлээн зөвшөөрөх нь тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны үр дүн болох мөнгөн орлого ба мөнгөн зарлагын талаархи мэдээллийг хүргэн танилцуулах зарим засгийн газруудын болон засгийн газрын байгууллагуудын санхүүгийн тайлангийн

чадвар боломжийг дордуулж болох юм. Иймээс дээрх 1.3.13-р параграфт дурдсан, нөхцөл байдалд мөнгөн орлого ба мөнгөн зарлагыг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах ба мөнгөн орлого, зарлагын тайланд цэвэр дүнгээр тайлагнахыг энэ Стандартаар зөвшөөрдөг.

### **Байгууллагын өмнөөс гуравдагч талын хийсэн төлбөр**

**1.3.24 *Тайлант үеийн туршид гуравдагч тал нь байгууллагын үүргийг шууд барагдуулсан эсвэл байгууллагын өмнөөс бараа, үйлчилгээг худалдан авсан бол тухайн байгууллага нь мөнгөн орлого, зарлагын тайлан дахь тусдаа баганад дараах зүйлсийг тодруулна:***

**(а) *Тухайн тайлагнагч байгууллагын харъяалагддаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг хэсэг болох гуравдагч талаас хийсэн нийт төлбөр, үүнд: уг тайлагнагч байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой ангиллын суурийг ашигласнаар тэрхүү нийт төлбөрийн эх үүсвэр ба зарцуулалтын дэд ангиллуудыг тусад нь харуулах; ба***

**(б) *Тухайн тайлагнагч байгууллагын харъяалагддаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг хэсэг болдоггүй гуравдагч талаас хийсэн нийт төлбөр, үүнд: уг тайлагнагч байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой ангиллын суурийг ашигласнаар тэрхүү нийт төлбөрийн эх үүсвэр ба зарцуулалтын дэд ангиллуудыг тусад нь харуулах;***

***Гуравдагч тал буюу хүлээн авагч нь тухайн тайлант үеийн туршид ийм төлбөр хийсэн гэдгээ уг байгууллагад албан ёсоор мэдэгдсэн эсвэл төлбөрийг бусад байдлаар шалгасан зөвхөн тийм тохиолдолд эдгээр тодруулгыг хийх хэрэгтэй.***

**1.3.25** Төвлөрсөн төрийн сангийн чиг үүрэг буюу “нэг данс”-ны зохицуулалтаар дамжуулан засгийн газар нь өөрийн бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын зарлагыг удирддаг тохиолдолд уг төв байгууллага нь тухайн хэлтэс газраас зохих зөвшөөрөл ба баримтжуулалтыг хүлээн авсны дараа тэдгээр бие даасан хэлтэс газрууд хэлтсүүд болон бусад байгууллагуудын өмнөөс төлбөрийг хийдэг. Ийм тохиолдолд хэлтэс газар болон бусад байгууллага нь мөнгөн орлогын гүйлгээ, мөнгөн зарлагын гүйлгээ болон мөнгөний үлдэгдлийг хянадаггүй. Гэвч уг хэлтэс газар буюу бусад байгууллага нь түүний өмнөөс хийгдсэн төлбөрөөс өгөөж хүртэх бөгөөд ийм төлбөрүүдийн дүнгийн талаархи мэдлэг нь тайлант үеийн туршид тухайн байгууллагын үйл ажиллагаанд зориулан засгийн газраас зарцуулсан мөнгөн нөөцийг тогтоох хэрэглэгчдэд хамааралтай байдаг. Дээрх 1.3.24(а) параграфт заасанчлан, хэлтэс газар буюу бусад байгууллага нь түүний өмнөөс төв байгууллагын хийсэн төлбөрийн дүнг мөнгөн орлого, зарлагын тайландаа тусдаа баганад тайлагнах бөгөөд уг зарцуулсан дүнгийн эх үүсвэр болон зарцуулалтыг тухайн хэлтэс газар буюу бусад байгууллагад тохиромжтой сууриар дэд ангилал үүсгэж харуулна. Эдгээр тодруулга нь хийгдсэн төлбөрийн нийт дүн, төлбөрийн зориулалт, төлбөрийг ямар эх үүсвэрээс, жишээлбэл, ерөнхий орлогоос

хуваарилагдсан буюу төсөвлөн хуваарилсан дүнгээс, эсвэл тусгай зориулалтын сангаас, эсвэл бусад эх үүсвэрээс хийсэн эсэхийг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог.

- 1.3.26 Зарим улс оронд засгийн газрын хэлтэс газрууд буюу бусад байгууллагуудыг өөрийн банкны харилцах данстайгаар үүсгэн байгуулж болох бөгөөд тэд зарим мөнгөн орлогын гүйлгээ, мөнгөн зарлагын гүйлгээ болон мөнгөний үлдэгдлээ хянах юм. Ийм улс орны хувьд нэг хэлтэс газар буюу засгийн газрын бусад байгууллага нь өөр хэлтэс газрын буюу байгууллагын зарим үүргийг барагдуулах, эсвэл өөр хэлтэс газрын болон байгууллагын өмнөөс зарим бараа, үйлчилгээг худалдан авахыг засгийн газрын чиглэл буюу заавраар бас шаардаж болох юм. Дээрх 1.3.24(а) параграфт заасанчлан, тайлагнагч байгууллага нь тайлант үеийн туршид түүний өмнөөс хийсэн төлбөрийн дүн, ийм зарлагын эх үүсвэр болон зарцуулалтыг мөнгөн орлого, зарлагын тайландаа тусдаа баганад тайлагнана. Энэ нь тайлант үеийн туршид тухайн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нийт мөнгөн нөөц, тэдгээр мөнгөн нөөцийн эх үүсвэр ба зарцуулалтыг тодорхойлоход хэрэглэгчдэд тусалдаг.
- 1.3.27 Зарим тохиолдолд, тайлагнагч байгууллагын харъяалагддаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг хэсэг болохгүй гуравдагч тал нь тухайн байгууллагын өмнөөс бараа, үйлчилгээг худалдан авах буюу түүний үүргийг барагдуулдаг. Жишээлбэл; үндэсний засгийн газар нь тухайн тайлант үеийн туршид үйлчилгээ нийлүүлэгчдэд төлбөрийг шууд төлөх эсвэл шаардлагатай хангамжийн зүйлсийг худалдан авч, бусад засгийн газарт шилжүүлэг хийх замаар бие даасан аймгийн буюу хотын захиргааны эрүүл мэндийн болон боловсролын хөтөлбөрийн үйл ажиллагааг санхүүжүүлж болох юм. Үүнтэй адилаар, үндэсний засгийн газар буюу хараат бус тусламжийн агентлаг нь тухайн нэг засгийн газарт зам барьж өгөхдөө мөнгө санг түүнд шууд олгохын оронд, барилгын компанид төлбөрийг шууд төлж болох юм. Эдгээр төлбөрийг буцалтгүй тусламж буюу бусад туслалцаа, эсвэл эргэн төлөгдөх зээл байдлаар олгож болно. Ийм тохиолдолд аймгийн болон хотын захиргаа нь мөнгийг (үүнтэй дотроо, мөнгөтэй адилтгах хөрөнгийг) шууд хүлээн авахгүй буюу түүний өмнөөс бусад байгууллагын үүсгэн бүрдүүлсэн банкны данс ба түүнтэй адилтгах хэрэгсэлд хяналт тогтоодоггүй. Иймээс түүний өмнөөс барагдуулсан буюу төлсөн дүн нь энэ Стандартад тодорхойлсон “мөнгө”-ийг бүрдүүлэхгүй. Гэвч тус засгийн газар нь түүний өмнөөс төлсөн мөнгөн зарлагаас өгөөж хүртэж байна.
- 1.3.28 Байгууллагын харъяалагддаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг хэсэг болохгүй гуравдагч талаас хийсэн төлбөрийн дүн, ийм зарлагын эх үүсвэр болон зарцуулалтыг тухайн байгууллага нь мөнгөн орлого, зарлагын тайландаа тусдаа баганад тайлагнахыг дээрх 1.3.24(б) параграфтаар шаардсан байдаг. Энэ нь тайлант үеийн туршид тухайн байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан нийт мөнгөн нөөц, тэдгээр нөөцийн хэдийг уг тайлагнагч байгууллага харъяалагддаг засгийн газрын бүрэлдэхүүн хэсэг болох талуудаас, хэдийг тус засгийн газрын бүрэлдэхүүн хэсэг биш

талуудаас олгосон гэдгийг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог. Зарим тохиолдолд байгууллага нь тайлант үеийн туршид түүний өмнөөс гуравдагч талын хийсэн төлбөрийн дүнг тухайн тайлант үеийн эцэст мэддэггүй байж болох юм. Гуравдагч талын төлсөн төлбөрийн талаар тухайн байгууллагад албан ёсоор мэдэгдээгүй буюу хүлээгдэж буй төлбөр хийгдсэн эсэхийг өөр бусад байдлаар шалгах боломжгүй бол ийм тохиолдол үүсэж болно. Тухайн тайлант үеийн туршид ийм төлбөр хийсэн гэдгийг уг байгууллагад албан ёсоор мэдэгдсэн эсвэл төлбөр төлөлтийг бусад байдлаар шалгасан зөвхөн тийм тохиолдолд гуравдагч талын төлбөрийг мөнгөн орлого, зарлагын тайланд тодруулахыг дээрх 1.3.24-р параграфт шаардсан байдаг.

- 1.3.29 1.3.24(а) ба 1.3.24(б) параграфуудын дагуу тодруулах тэдгээр гуравдагч талын төлбөрүүдийн эх үүсвэр болон зарцуулалтын дэд ангиллууд (буюу ангиуд) нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал юм. Уг шүүн тунгаалтыг хийхдээ харгалзах хүчин зүйлсийг 1.3.17-р параграфт заасан.

## **Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тайлбар тэмдэглэл**

### **Тэмдэглэлийн бүтэц**

#### **1.3.30 *Байгууллагын санхүүгийн тайлангийн тэмдэглэлд:***

- (а) ***Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь болон мэдэгдэхүйц ажил гүйлгээ, бусад үйл явдлын хувьд сонгосон ба мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогын талаархи мэдээллийг толилуулах хэрэгтэй; ба***
- (б) ***Санхүүгийн тайланд толилуулаагүй боловч байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага болон мөнгөний үлдэгдлийн үнэн зөв толилуулгад шаардлагатай нэмэлт мэдээллийг тусгах хэрэгтэй.***

- 1.3.31 ***Санхүүгийн тайлангийн тэмдэглэлийг системчилсэн арга маягаар толилуулах хэрэгтэй. Мөнгөн орлого, зарлагын тайлан болон бусад санхүүгийн тайлангийн мөрийн зүйл нэг бүрийг тэмдэглэл дэх аливаа холбогдох мэдээлэлтэй харилцан лавлагаа үүсгэвэл зохино.***

### **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт ба тодруулга**

#### **1.3.32 *Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд дараах шаардлагуудыг хангасан мэдээллийг толилуулах хэрэгтэй:***

- (а) ***Ойлгомжтой;***
- (б) ***Хэрэглэгчдийн шийдвэр гаргалтын болон хариуцлагын хэрэгцээ шаардлагад хамааралтай; ба***
- (в) ***Доорх нөхцлүүдийг хангасан найдвартай:***

- (i) Байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдэл болон тодруулсан бусад мэдээллийг үнэн зөв илэрхийлэх;*
- (ii) Аль нэг тал руу хэлбийгээгүй төв голч байх; ба*
- (iii) Бүх материаллаг зүйлсийн хувьд иж бүрэн байх.*

- 1.3.33 Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн чанар нь хэрэглэгчдэд уг тайлангийн үзүүлэх ач холбогдлыг тодорхойлдог. Санхүүгийн тайлан нь олон тооны чанарын шинжүүдийг биелүүлэх тийм мэдээллээр хангадаг гэдгийг магадлан баталгаажуулах нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулахыг 1.3.32-р параграфтаар шаардсан байдаг. Санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг энэ Стандартын Хавсралт 4-д товчоолон харуулсан. Мэдээлэл цаг хугацаандаа байх нь санхүүгийн мэдээллийн хамааралтай ба найдвартай байдалд мөн нөлөө үзүүлж болно гэдгийг уг Хавсралтанд бас дурдсан. Тайлант үеийн туршид бүрэн гүйцэд ба үнэн зөв нягтлан бодох бүртгэл хөтлөх нь нийтлэг зорилготой санхүүгийн тайланг цаг хугацаанд нь бэлтгэхэд чухал ач холбогдолтой юм.
- 1.3.34 *Санхүүгийн тайлангийн талаархи зохих ойлголтонд зайлшгүй шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого нэг бүрийг, үүн дотроо энэ Стандартын аливаа шилжилтийн нөхцлүүдийг уг байгууллага даган мөрдсөн хэмжээг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого хэсэгт тайлбарлах хэрэгтэй.*
- 1.3.35 *Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга эсвэл тэмдэглэл буюу тайлбар материал оруулах замаар тухайн тохиромжгүй нягтлан бодох бүртгэлийн бодлогыг засаж залруулж чадахгүй юм.*
- 1.3.36 Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогыг тодруулах хэрэгтэй эсэхийг шийдвэрлэхдээ, удирдлага нь тухайн тайлагнасан мөнгөн орлого, зарлага болон мөнгөний үлдэгдэлд тэдгээр ажил гүйлгээ, үйл явдлуудыг тусгасан арга замыг ойлгоход тэрхүү тодруулга хэрэглэгчдэд туслах эсэхийг харгалзан үзнэ. Хэдийгээр тайлант болон өмнөх үеүдэд харуулсан дүнгүүд нь материаллаг бус боловч нягтлан бодох бүртгэлийн бодлого нь чухал ач холбогдолтой байж болно. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тайлбар тэмдэглэлийг агуулсан байна гэдгийг энэ Стандартын 1.3.4-р параграфт заасан. Иймээс дээрх 1.3.34-р параграфын шаардлагуудыг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд бас мөрдөнө.
- 1.3.37 *Байгууллага нь энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн аливаа тодруулгыг өөрийн санхүүгийн тайланд тусган оруулах сонголт хийсэн тохиолдолд тэдгээр тодруулга нь дээрх 1.3.32-р параграфын шаардлагуудтай нийцсэн байвал зохино.*

1.3.38 Нэмэлт мэдээллийн тодруулгыг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусгахыг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн. Ийм тодруулгыг хийсэн тохиолдолд тэдгээр нь ойлгомжтой бөгөөд санхүүгийн мэдээллийн бусад чанарын шинжүүдийг хангасан байх шаардлагатай юм.

## 1.4 Ерөнхий асуудлууд

### Тайлант үе

1.4.1 ***Нийтлэг зорилготой санхүүгийн тайланг наад зах нь жил бүр толилуулна. Байгууллагын тайлангийн өдөр өөрчлөгдсөн ба жилийн санхүүгийн тайланг нэг жилээс урт эсвэл богино хугацаагаар толилуулсан хэвийн бус нөхцөл байдалд байгууллага нь тухайн санхүүгийн тайлангийн хамрах тайлант үеэс гадна дараах зүйлсийг тодруулна:***

(а) ***Нэг жилээс өөр хугацааг ашигласан шалтгаан (шалтгаанууд); ба***

(б) ***Зэрэгцүүлэгдэх дүнгүүд нь бүхэлдээ зэрэгцүүлэгдэх боломжгүй болсон тухай.***

1.4.2 Тайлангийн өдөр гэдэг нь тухайн санхүүгийн тайлангийн хамаарах тайлант үеийн сүүлчийн өдөр юм. Онцгой нөхцөл байдалд, байгууллага нь тухайлбал, тайлагналын циклийг төсөвлөлтийн циклтэй илүү нийцүүлэхийн тулд өөрийн тайлангийн өдрийг өөрчлөхөөр шийдвэрлэж, эсвэл түүнээс ингэж өөрчлөхийг шаардаж болно. Ийм тохиолдолд тайлангийн өдрийн өөрчлөлтийн шалтгааныг тодруулах ба хэрэглэгчид нь тухайн тайлант үеийн хувьд харуулсан дүнгүүд, түүнчлэн зэрэгцүүлэгдэх дүнгүүд нь зэрэгцүүлэгдэх боломжгүй болсон гэдгийг мэдэж байх нь чухал ач холбогдолтой юм.

1.4.3 Ерөнхийдөө, нэг жилийн хугацаанд хамаарах санхүүгийн тайланг тууштай бэлтгэж, толилуулдаг. Гэвч практик шалтгааны улмаас зарим байгууллага нь өөр, тухайлбал; 52 долоо хоногийн хугацаагаар тайлагнахыг илүүд үздэг. Ингэж толилуулсан санхүүгийн тайлан нь нэг жилээр толилуулсан санхүүгийн тайлангаас материаллаг зөрүүтэй байх магадлал багатай учраас энэ Стандарт нь ийм практикыг хориглодоггүй.

### Цаг хугацаандаа байх

1.4.4 Тайлангийн өдрөөс хойшхи ул үндэслэлтэй хугацааны дотор санхүүгийн тайланг хэрэглэгчдэд хүргэн танилцуулахгүй бол түүний ач холбогдолтой байдал буурдаг. Хэдийгээр гурван сараас илүүгүй хугацааг хүчтэй дэмждэг боловч байгууллага нь тухайн тайлангийн өдрөөс хойш 6 сарын дотор өөрийн санхүүгийн тайланг гарган танилцуулах байр суурьтай байвал зохино. Байгууллагын үйл ажиллагааны нарийн цогц байдал гэх мэт байнгын хүчин зүйлс нь санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гарган тайлагнаж чадахгүй байх хангалттай зохих шалтгаан биш юм. Илүү

тусгайлсан эцсийн хугацааг олон улс оронд хууль тогтоомж болон зохицуулалтанд заасан байдаг.

### **Зөвшөөрсөн өдөр**

- 1.4.5 ***Байгууллага нь санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдөр болон уг зөвшөөрлийг хэн өгсөн талаар тодруулга хийнэ. Хэрэв өөр нэг этгээд нь санхүүгийн тайланг нийтэд гаргасны дараа түүнд өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй бол уг байгууллага нь энэ тухай тодруулга хийнэ.***
- 1.4.6 Нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдөр нь санхүүгийн тайланг нийтэд гаргахын тулд эцэслэн дуусгах бүрэн эрх бүхий хувь хүн буюу байгууллагаас тухайн санхүүгийн тайлангийн хувьд зөвшөөрөл авсан өдөр юм. Санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрөөс хойшхи үйл явдлыг уг санхүүгийн тайланд тусгадаггүй тул тэрхүү өдрийг мэдэж байх нь хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг. Санхүүгийн тайланг нийтэд гаргасны дараа аливаа нэг этгээд буюу байгууллага нь түүнд нэмэлт өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй байх цөөн ховор тохиолдлыг хэрэглэгч нар мэдэж байх нь мөн чухал ач холбогдолтой юм. Санхүүгийн тайланг нийтэд гаргасны дараа түүнд нэмэлт өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй байж болох хувь хүн буюу этгээдийн жишээнд Сайд нар, тухайн байгууллага нэг хэсэг нь болдог засгийн газар, Улсын Их Хурал, иргэдийн төлөөлөгчдийн хурал хамаарна. Хэрэв өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлт оруулсан санхүүгийн тайлан нь шинэ цогц санхүүгийн тайлан болно.

### **Байгууллагын тухай мэдээлэл**

- 1.4.7 ***Санхүүгийн тайлангийн хамт хэвлэн нийтэлсэн мэдээллийн аль нэг хэсэгт толилуулаагүй бол байгууллага нь дараах зүйлсийг толилуулна:***
- (a) ***Байгууллагын байнга оршин суух газар ба хуулийн хэлбэр, түүний үйл ажиллагаагаа явуулдаг улс орон;***
  - (б) ***Байгууллагын үйл ажиллагааны шинж төрөл ба түүний үндсэн үйл ажиллагаануудын талаархи тайлбар тодорхойлолт;***
  - (в) ***Хэрэв байдаг бол тухайн байгууллагын үйл ажиллагааг удирдан зохицуулах холбогдох хууль тогтоомжийн талаархи лавлагаа; ба***
  - (е) ***Хянагч байгууллагын нэр болон эдийн засгийн нэгдмэл байгууллагын эцсийн хянагч байгууллагын нэр (хамааралтай тохиолдолд).***
- 1.4.8 1.4.7-р параграфтаар шаардсан мэдээллийн тодруулга нь тухайн байгууллагын үйл ажиллагааны шинж төрлийг тодорхойлох, түүний үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн болон зохицуулалтын орчны талаар ойлголттой болох боломжийг хэрэглэгчдэд олгодог. Энэ нь хариуцлагын



зорилгын хувьд зайлшгүй шаардлагатай бөгөөд тухайн байгууллагын санхүүгийн тайланг ойлгож, үнэлэхэд хэрэглэгчдэд тусална.

### **Мөнгөний үлдэгдэлд болон зээл авахад тавигдах хязгаарлалт**

**1.4.9 Байгууллага нь дараах зүйлсийн шинж төрөл ба дүнг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд холбогдох тайлбарын хамтаар тодруулна:**

- (а) **Тухайн байгууллага ашиглах боломжгүй мэдэгдэхүйц дүнтэй мөнгөний үлдэгдэл;**
- (б) **Гаднын хязгаарлалт тавигдсан мэдэгдэхүйц дүнтэй мөнгөний үлдэгдэл; ба**
- (в) **Ирээдүйн үйл ажиллагаанд болон капиталын хариуцлагыг биелүүлэхэд ашиглагдах боломжтой боловч ашиглан зарцуулаагүй байгаа зээлийн эх үүсвэрийн дүн, мөн тэдгээр эх үүсвэрийн ашиглалтанд тавигдах аливаа хязгаарлалтуудыг илэрхийлэх.**

1.4.10 Байгууллагын эзэмшиж буй мөнгөний үлдэгдэл нь тухайн байгууллагад ашиглагдах боломжгүй нөхцөл байдлууд байдаг. Жишээлбэл; хяналтанд буй байгууллага нь валютын зохицуулалт буюу эрх зүйн бусад хязгаарлалтыг мөрддөг улс оронд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд түүний мөнгөний үлдэгдлийг тухайн хяналт тавигч байгууллага болон хяналтанд буй бусад байгууллагууд нь ерөнхий хэрэгцээнд зориулан ашиглан зарцуулах боломжгүй байдаг.

1.4.11 Байгууллагын хянаж буй мөнгөний үлдэгдэл нь түүний ашиглалтын зориулалт буюу хугацааг заасан хязгаарлалтанд захирагддаг байж болно. Байгууллага нь тусгай зорилгод ашиглах ёстой буцалтгүй тусламж буюу хандив хүлээн авсан тохиолдолд ийм нөхцөл байдал байнга үүсдэг. Байгууллага нь агент болохын хувьд түүний бүрэн эрхийн хүрээнд бусад талуудын өмнөөс цуглуулсан боловч тэдгээр талуудад хараахан шилжүүлээгүй байгаа мөнгийг тухайн тайлангийн өдрөөр өөрийн банкны дансандаа байршуулан эзэмшиж байгаа тохиолдолд ийм нөхцөл байдал бас үүсэж болох юм. Хэдийгээр байгууллага нь тэдгээр мөнгөний үлдэгдлийг хянаж, өөрийн мөнгөний үлдэгдэл байдлаар тайлагнасан боловч ийм зүйлсийн дүнгийн талаархи тусдаа тодруулга нь хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг.

1.4.12 Зарцуулаагүй зээлийн хэрэгсэл нь тухайн байгууллагын мөнгөний боломжит эх үүсвэрийг илэрхийлнэ. Эдгээр хэрэгслүүдийн дүнгийн гол төрлөөр харуулсан тодруулга нь ийм мөнгөний бэлэн боломжтой байдал ба тухайн тайлант үеийн туршид түүнээс байгууллагын ашиглан зарцуулсан хэмжээг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог.

## **Толилуулгын тууштай байдал**

**1.4.13 Доор дурдснаас бусад тохиолдолд, санхүүгийн тайлан дахь зүйлсийн толилуулга ба ангиллыг нэг тайлант үеэс дараагийн тайлант үед хэвээр хадгална:**

**(а) Байгууллагын үйл ажиллагааны шинж төрлийн мэдэгдэхүйц өөрчлөлт эсвэл түүний санхүүгийн тайлангийн нягтлах шалгалт нь ийм өөрчлөлт хийснээр үйл явдал буюу ажил гүйлгээний илүү тохиромжтой толилуулгад хүргэнэ гэдгийг харуулсан; эсвэл**

**(б) Энэ Стандартад ирээдүйд оруулах нэмэлт өөрчлөлт нь толилуулгыг өөрчлөхийг шаардах.**

1.4.14 Үйлчилгээ үзүүлэх хэлцлийн томоохон өөрчлөлт, засгийн газрын шинэ байгууллага үүсгэн байгуулалт эсвэл одоо байгаа гол байгууллагыг татан буулгалт, томоохон худалдан авалт буюу данснаас хасалт, тухайн байгууллагын нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгын нягтлах шалгалт нь мөнгөн орлого, зарлагын тайлан буюу бие даасан бусад санхүүгийн тайланг өөрөөр толилуулах хэрэгтэй гэдгийг илэрхийлж болох юм. Жишээлбэл; засгийн газар нь өөрийн хяналтанд буй хамгийн том байгууллагуудын нэг болох хадгаламжийн банкыг данснаас хассан ба үлдсэн бусад эдийн засгийн нэгдмэл байгууллага нь үндсэндээ захиргааны болон бодлогын зөвлөх үйлчилгээг эрхлэн явуулж болох юм. Энэ тохиолдолд санхүүгийн байгууллага гэсэн уг засгийн газрын үндсэн үйл ажиллагаанд үндэслэсэн санхүүгийн тайлангийн толилуулга нь хамааралтай байх магадлал багатай юм.

1.4.15 Уг өөрчилсөн бүтцийг цааш үргэлжлүүлэх магадлалтай буюу хувилбар толилуулгын үр өгөөж тодорхой байх зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь өөрийн санхүүгийн тайлангийн толилуулгыг өөрчилнө. Толилуулгад ийм өөрчлөлт хийсэн тохиолдолд байгууллага нь өөрийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг 1.4.19-р параграфын дагуу дахин ангилна. Байгууллага нь энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартыг мөрддөг бол үндэсний шаардлагуудыг даган мөрдөхийн тулд хийх толилуулгын өөрчлөлт нь энэ Стандартын шаардлагуудтай нийцэх зөвхөн тийм тохиолдолд толилуулгын өөрчлөлт хийхийг түүнд зөвшөөрнө.

## **Зэрэгцүүлэгдэх мэдээлэл**

**1.4.16 Энэ Стандартын нөхцөл заалт өөрөөр шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага нь энэхүү Стандартыг анх удаа мөрдөж буй тайлант үеийн санхүүгийн тайлангаас бусад, тэдгээр санхүүгийн тайланд тусгахыг тус Стандартаар шаардсан бүх тоон мэдээллийн хувьд харгалзах өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулна. Хэрэв тухайн тайлант үеийн санхүүгийн тайланг ойлгоход хамааралтай бол хүүрнэсэн ба тайлбарласан мэдээллийн хувьд мөн зэрэгцүүлэгдэх мэдээллийг тусган оруулна.**

- 1.4.17 Энэ Стандарт нь мөнгөн орлого, зарлагын тайланг толилуулахыг шаарддаг бөгөөд тухайн тайланд болон түүний тэмдэглэлд тусган оруулах хэрэгтэй зарим тодруулгыг тусгайлан заасан. Нэмэлт санхүүгийн тайлан бэлтгэхийг энэ Стандартаар хориглодоггүй. Зарим нэмэлт тодруулга хийхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн байдаг. Мөнгөн орлого, зарлагын тайлангаас гадна санхүүгийн тайланг бэлтгэсэн буюу энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн тодруулгыг хийсэн тохиолдолд зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулга хийхийг мөн сайшаан дэмжинэ.
- 1.4.18 Зарим тохиолдолд өмнөх тайлант үеийн (үеүдийн) санхүүгийн тайланд тусгасан, хүүрнэсэн мэдээлэл нь тухайн тайлант үед мөн хамааралтай хэвээр байдаг. Жишээлбэл; өмнөх тайлант үеийн эцсээр үр дагавар нь тодорхойгүй буюу хараахан шийдэгдээгүй байсан хуулийн зарга маргааны талаархи дэлгэрэнгүй мэдээллийг байгууллага нь тухайн тайлант үед тусган тодруулдаг. Өмнөх тайлант үеийн эцэст байсан тодорхойгүй зүйлсийн талаархи мэдээллийн тодруулга ба уг тодорхойгүй байдлыг шийдвэрлэхийн тулд тухайн тайлант үеийн туршид авсан арга хэмжээний талаархи мэдээллийн тодруулга нь хэрэглэгчдэд ач холбогдолтой байж болно.
- 1.4.19 ***Санхүүгийн тайланд тодруулах шаардлагатай зүйлсийн толилуулга буюу ангилалд нэмэлт өөрчлөлт оруулсан бол тухайн тайлант үетэй зэрэгцүүлэгдэх боломжтой байдлыг хангахын тулд дахин ангилал хийх практик боломжгүй байхаас бусад тохиолдолд зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг дахин ангилах бөгөөд ийм аливаа дахин ангиллын шинж төрөл, дүн, шалтгааныг тодруулах хэрэгтэй. Зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг дахин ангилах практик боломжгүй тохиолдолд байгууллага нь дүнгүүдийг дахин ангилаагүй шалтгаан, хэрэв дүнгүүдийг дахин ангилсан бол хийгдэх байсан өөрчлөлтийн шинж төрлийг тодруулах хэрэгтэй.***
- 1.4.20 Тайлант үетэй зэрэгцүүлэлт хийхийн тулд өмнөх тодорхой тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг зарим тохиолдолд дахин ангилах практик боломжгүй байдаг. Жишээлбэл; дахин ангилал хийх боломжтой байдлаар өмнөх тайлант үеүдийн мэдээг цуглуулан бүрдүүлээгүй ба уг мэдээллийг дахин бүрдүүлэх практик боломжгүй байж болох юм. Ийм тохиолдолд зэрэгцүүлэгдэх дүнгүүдэд хийх байсан залруулгын шинж төрлийг тодруулна.

### **Санхүүгийн тайлангийн ялган тодорхойлолт**

- 1.4.21 ***Санхүүгийн тайланг ойлгомжтой байдлаар ялган тодорхойлох ба хэвлэн нийтэлж буй баримт бичиг дэх бусад мэдээллээс ялган илэрхийлэх хэрэгтэй.***
- 1.4.22 Энэ Стандартыг зөвхөн санхүүгийн тайланд мөрдөх бөгөөд жилийн тайлан илтгэл буюу өөр бусад баримт бичигт толилуулж буй бусад мэдээлэлд мөрдөхгүй. Иймээс хэрэглэгчид нь энэ Стандартыг ашиглан бэлтгэсэн

мэдээллийг тэдэнд ач холбогдолтой байж болох боловч стандартын шаардлагуудад хамаарахгүй бусад мэдээллээс ялган зааглаж чадахаар байх нь чухал ач холбогдолтой юм.

**1.4.23 Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг ойлгомжтой байдлаар ялган тодорхойлох хэрэгтэй. Түүнчлэн, дараах мэдээллийг тов тодорхой харуулах ба толилуулж буй мэдээллийг зөв ойлгоход зайлшгүй шаардлагатай тохиолдолд давтан илэрхийлнэ:**

- (а) **Тайлагнагч байгууллагын нэр буюу ялган тодорхойлох бусад илэрхийлэлт;**
- (б) **Бие даасан байгууллагын эсвэл эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайлан эсэх;**
- (в) **Санхүүгийн тайланд хамаарах тайлангийн өдөр буюу хамрагдах тайлант үе, энэ нь санхүүгийн тайлангийн тухайн бүрэлдэхүүн хэсгийн хувьд тохиромжтой эсэх;**
- (г) **Толилуулгын валют; ба**
- (д) **Санхүүгийн тайланд дүнг толилуулахдаа хэрэглэсэн бүхэлчлэлийн түвшин.**

**1.4.24** Санхүүгийн тайлангийн хуудас бүрийн хувьд хуудасны нэр гарчиг болон баганын толгойн хураангуйлсан нэрийг бичсэнээр 1.4.23-р параграфт заасан шаардлагуудыг үндсэндээ ханган биелүүлнэ. Ийм мэдээллийг толилуулах хамгийн сайн арга замыг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Жишээлбэл; санхүүгийн тайланг цахим хэлбэрээр толилуулах тохиолдолд тусдаа хуудсуудыг байнга ашиглах шаардлагагүй байж болно. Тухайн тусгасан мэдээллийн ойлгомжтой байдлыг хангахын тулд 1.4.23-р параграфт заасан зүйлсийг байнга толилуулна.

**1.4.25** Толилуулгын валютын мянгачилсан эсвэл саячилсан дүнгээр мэдээллийг толилуулснаар санхүүгийн тайланг ойлгоход ихэвчлэн илүү хялбар болгодог. Толилуулга дахь бүхэлчлэлийн түвшинг заасан бөгөөд материаллаг мэдээллийг орхигдуулаагүй тохиолдолд ингэж бүхэлчлэхийг зөвшөөрнө.

## **1.5 Алдааны засварлалт**

**1.5.1 Санхүүгийн тайланд тайлагнасан мөнгөний үлдэгдэлтэй холбоотой алдаа гарсан тохиолдолд тухайн тайлант үеийн эхэн дэх мөнгийг залруулснаар уг өмнөх тайлант үеүдэд хамаарах алдааны дүнг тайлагнана. Зэрэгцүүлэгдэх мэдээллийг практик боломжгүй байхаас бусад тохиолдолд дахин илэрхийлнэ.**

**1.5.2 Байгууллага нь санхүүгийн тайлангийн тэмдэглэлд дараах зүйлсийг тодруулна:**

- (а) *Алдааны шинж төрөл;*
- (б) *Засварлалтын дүн; ба*
- (в) *Зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин илэрхийлсэн эсвэл ингэж дахин илэрхийлэх практик боломжгүй тухай.*

- 1.5.3 Нэг буюу хэд хэдэн өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайланг бэлтгэхэд гарсан алдааг тухайн тайлант үед илрүүлж болох юм. Математик үйлдлийн алдаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхөд гаргасан алдаа, баримт материалын буруу тайлбарлалт, хайнга хандалт, зальт ажиллагааны улмаас алдаа гарч болох юм. Өмнөх тайлант үеийн хувьд алдаа илрүүлсэн тохиолдолд алдаа ба санхүүгийн тайланг, үүн дотроо өмнөх тайлант үеүдийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг засварлахын тулд мөнгөний эхний үлдэгдлийг залруулах бөгөөд уг алдаа гаргасан тайлант үед түүнийг засварласан мэтээр толилуулна. Алдаа ба түүний залруулгын талаархи тайлбарыг тэмдэглэлд тусгана.
- 1.5.4 Зэрэгцүүлэгдэх мэдээллийн дахин илэрхийлэлт нь удирдах байгууллагаас баталсан, эсвэл зохицуулалтын эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн буюу тушааж танилцуулсан санхүүгийн тайланд заавал нэмэлт өөрчлөлт оруулах албагүй юм. Гэвч ийм санхүүгийн тайланд нэмэлт өөрчлөлт оруулахыг үндэсний хууль тогтоомжоор шаардаж болох юм.
- 1.5.5 Энэ Стандарт нь мөнгөн орлого, зарлагын тайлан толилуулахыг шаардах бөгөөд бусад санхүүгийн тайлан толилуулахыг хориглодоггүй. Мөнгөн орлого, зарлагын тайлангаас гадна санхүүгийн тайланг толилуулах тохиолдолд алдааны засварлалтын талаархи 1.5.1 ба 1.5.2-р параграфын шаардлагуудыг тэдгээр тайланд бас мөрдөнө.

## **1.6 Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

### **Тодорхойлолт**

- 1.6.1 *Дараах нэр томъёог энэ Стандартад доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:*

*Нэгтгэсэн санхүүгийн тайлан гэдэг нь нэг нэгж байдлаар толилуулдаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайлан юм.*

*Байгууллагын хяналт гэдэг нь нөгөө байгууллагын үйл ажиллагаанаас өгөөж хүртэхийн тулд түүний санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг удирдах бүрэн эрх юм.*

*Хяналтанд буй байгууллага гэдэг нь өөр байгууллагын (хяналт тавигч байгууллага гэж нэрлэдэг) хяналтанд байдаг байгууллага юм.*

*Хяналт тавигч байгууллага гэдэг нь нэг буюу хэд хэдэн байгууллагыг хянадаг байгууллага юм.*

**Эдийн засгийн нэгдмэл байгууллага гэдэг нь хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй нэг буюу хэд хэдэн байгууллагуудаас бүрдэх байгууллагуудын групп юм.**

#### **Эдийн засгийн нэгдмэл байгууллага**

- 1.6.2 Хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй аливаа байгууллагуудаас бүрдэх байгууллагуудын группыг санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлохын тулд энэ Стандартад “эдийн засгийн нэгдмэл байгууллага” гэсэн нэр томъёог ашигласан.
- 1.6.3 Эдийн засгийн нэгдмэл байгууллагыг илэрхийлэхийн тулд зарим үед “захиргааны байгууллага”, “санхүүгийн тайлагнагч байгууллага”, “нэгтгэсэн байгууллага”, “групп” гэх мэт нэр томъёог ашигладаг.
- 1.6.4 Эдийн засгийн нэгдмэл байгууллага нь нийгмийн бодлогын болон арилжааны аль аль зорилго бүхий байгууллагуудыг агуулсан байж болно. Жишээлбэл; засгийн газрын орон сууцны хэлтэс нь нэрлэсэн төлбөртэй орон сууцаар хангадаг байгууллагууд болон арилжааны сууриар орон сууцаар хангадаг байгууллагуудыг агуулсан эдийн засгийн нэгдмэл байгууллага байж болох юм.

#### **Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн цар хүрээ**

- 1.6.5 ***1.6.7 ба 1.6.8-р параграфт заасан хяналт тавигч байгууллагаас бусад, хяналт тавигч байгууллага нь 1.6.6-р параграфт дурдсанаас бусад, гадаад болон дотоодын бүх хяналтанд буй байгууллагуудыг хамруулсан, тийм нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж гаргана.***
- 1.6.6 ***Хяналтанд буй байгууллагын үйл ажиллагаанаас хяналт тавигч байгууллага үр өгөөж хүртэхэд саад учруулах, гаднын урт хугацааны хатуу хязгаарлалтуудын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг хяналтанд буй байгууллагыг нэгтгэлд оруулахгүй.***
- 1.6.7 ***Бүрэн өмчлөлт хяналтанд буй байгууллага болох хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэрэглэгчид оршин байх магадлал багатай эсвэл тэдгээрийн мэдээллийн хэрэгцээг тухайн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар хангадаг тохиолдолд тус хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулах шаардлагагүй юм.***
- 1.6.8 ***Бараг бүрэн өмчлөлт хяналтанд буй байгууллага болох хяналт тавигч байгууллага нь цөөнхийн хувь оролцооны эздээс зөвшөөрөл авсан бол нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулах шаардлагагүй юм.***
- 1.6.9 Засгийн газрын буюу улсын секторын бусад хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь бүхэлдээ тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хянаж буй мөнгөн нөөцийг ихэвчлэн сонирхдог

бөгөөд энэ талаар тэдэнд мэдээлэх шаардлагатай байдаг. Бие даасан хуулийн этгээдүүдийн эрх зүйн хил хязгаарыг үл харгалзан эдийн засгийн нэгдмэл байгууллагын талаархи санхүүгийн мэдээллийг нэг байгууллага мэтээр толилуулдаг нэгтгэсэн санхүүгийн тайлан нь энэ хэрэгцээ шаардлагыг хангадаг.

- 1.6.10 Тайлагнагч байгууллага нь мөнгөн орлого, зарлагын тайлан бэлтгэхийг энэ Стандартын 1.3.4-р параграфт шаардсан байдаг. Дээрх 1.6.5-р параграфын шаардлагуудын дагуу, хяналт тавигч байгууллага болох засгийн газар буюу улсын секторын бусад тайлагнагч байгууллага нь өөрийн хянаж буй бүх байгууллагуудын мөнгөн орлого, мөнгөн зарлага болон мөнгөний үлдэгдлийг нэгтгэнэ. Энэ Стандартын Нэгдүгээр хэсэгт шаардсан, тэмдэглэл тодруулгуудыг мөн нэгтгэсэн сууриар бэлтгэнэ. Санхүүгийн тайлагнагч байгууллагыг тодорхойлохдоо, хяналтын ойлголт ухагдахууныг хэрхэн ашиглахыг энэ Стандартын Хавсралт 5-д үлгэрчлэн харуулсан.
- 1.6.11 Мөнгөн орлого, зарлагын тайлангаас гадна санхүүгийн тайлан бэлтгэхийг энэ Стандартаар хориглодоггүй. Эдгээр нэмэлт тайлан нь тухайлбал, зарим сангийн бүлгүүдтэй холбоотой мөнгөн орлого, мөнгөн зарлагын талаархи нэмэлт мэдээллийг тодруулж, эсвэл мөнгөн гүйлгээний зарим төрлийн нэмэлт дэлгэрэнгүй мэдээллээр хангаж болох юм. Тодруулга хийхийг байгууллагад сайшаан дэмжсэн нэмэлт тодруулгуудыг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт тодорхойлсон. Эдгээр нэмэлт тайлан ба тодруулга нь тохиромжтой бол нэгтгэсэн мэдээллийг бас тайлагнадаг.
- 1.6.12 Санхүүгийн тайлагналын зорилгоор, тайлагнагч байгууллага (санхүүгийн тайлагнагч байгууллага) нь хяналтанд буй олон байгууллагуудаас, үүн дотроо засгийн газрын хэлтэс газрууд, агентлагууд болон Улсын Үйлдвэрийн Газраас (УҮГ) бүрдэж болох юм. Боломжит маш олон байгууллагуудын улмаас санхүүгийн тайлагнагч байгууллагын цар хүрээг тодорхойлоход төвөгтэй байж болно. Ийм учраас санхүүгийн тайлагнагч байгууллагуудыг ихэвчлэн хууль тогтоомжоор тодорхойлдог. Зарим тохиолдолд энэ Стандартаар шаардсан санхүүгийн тайлагнагч байгууллага нь хууль тогтоомжид тусгайлан заасан тайлагнагч байгууллагаас өөр байж болох бөгөөд тухайн хууль тогтоомжийн тайлагналын шаардлагуудыг хангахын тулд нэмэлт тодруулга шаардлагатай байж болох юм.
- 1.6.13 Өөр байгууллагын бүрэн өмчлөлд байдаг хяналт тавигч байгууллагын (засгийн газрын бүрэн өмчлөлт уг засгийн газрын агентлаг гэх мэт) нэгтгэсэн санхүүгийн тайланг түүний хяналт тавигч байгууллага шаардаагүй бөгөөд бусад хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг түүний уг хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар хамгийн сайн хангадаг тохиолдолд ийм бүрэн өмчлөлт хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулах шаардлагагүй юм. Гэвч улсын секторын хувьд бүрэн өмчлөлт буюу бараг бүрэн өмчлөлт хяналт тавигч олон байгууллагууд нь засгийн газрын гол секторууд буюу үйл ажиллагааг төлөөлөн илэрхийлдэг. Ийм тохиолдолд зөвхөн нийт засгийн газрын

түвшин дэх нэгтгэсэн санхүүгийн тайлангийн толилуулга нь зарим хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг бүрэн хангахгүй байж болох бөгөөд энэ Стандартын зорилго нь нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхээс тэдгээр байгууллагуудыг чөлөөлөхгүй байх явдал юм. Олон улс оронд засгийн газрууд нь үүнийг хүлээн зөвшөөрч, тэдгээр байгууллагын санхүүгийн тайлагналын шаардлагуудыг хуульчлан тогтоодог.

- 1.6.14 Зарим улс оронд хэрэв хяналт тавигч байгууллага нь цөөнхийн хувь оролцоо эзэмшигчдээс зөвшөөрөл авсан бол өөр байгууллагын бараг бүрэн өмчлөлт, хяналт тавигч байгууллага (хувийн секторын багахан өмчлөл бүхий засгийн газрын аж ахуйн нэгж гэх мэт) нь нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулахаас бас чөлөөлөгддөг. Бараг бүрэн өмчлөлт гэдэг нь саналын эрхийн 90 буюу түүнээс дээш хувийг тухайн хяналт тавигч байгууллага өмчилдөг гэсэн утгыг илэрхийлдэг. Энэ Стандартын зорилгын хувьд цөөнхийн хувь оролцоо гэдэг нь хяналт тавигч байгууллага шууд эсвэл хяналтанд буй байгууллагуудаар дамжуулан шууд бусаар өмчилдөггүй хувь оролцоонд хамаарах тухайн хяналтанд буй байгууллагын хэсэг юм.
- 1.6.15 Зарим тохиолдолд эдийн засгийн нэгдмэл байгууллага нь хяналт тавигч завсрын олон байгууллагуудыг өөртөө агуулсан байдаг. Жишээлбэл; эрүүл мэндийн газар нь хяналт тавигч байгууллага боловч орон нутгийн буюу бүсийн эрүүл мэндийн удирдлагын түвшний хяналт тавигч завсрын байгууллагууд байж болох юм. Улс орон бүрийн хариуцлагын болон тайлагналын шаардлагууд нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх шаардлагатай (эсвэл уг шаардлагаас чөлөөлөгдөх) байгууллагуудыг тусгайлан зааж болно. Хяналт тавигч завсрын байгууллагын хувьд нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх тусгай шаардлага байдаггүй боловч уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн хэрэглэгчид оршин байх магадлалтай тохиолдолд хяналт тавигч завсрын байгууллагууд нь ийм нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэж, хэвлэн нийтлэхийг сайшаан дэмжинэ.

## **Нэгтгэлийн горим**

### **1.6.16 *Нэгтгэлийн дараах горимуудыг мөрдөнө:***

- (а) ***Мөнгөний үлдэгдлүүд ба эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох мөнгөн ажил гүйлгээг бүхэлд нь устгаж цэвэрлэнэ;***
- (б) ***Нэгтгэлд ашигласан санхүүгийн тайлангуудыг өөр өөр тайлангийн өдрөөр бэлтгэсэн тохиолдолд тэдгээр өдрүүд ба уг хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайлангийн өдрийн хооронд гарч тохиолдсон мэдэгдэхүйн дүнтэй мөнгөн ажил гүйлгээнүүдийн үр нөлөөний хувьд залруулга хийнэ. Аливаа тохиолдолд тайлангийн өдрүүдийн хоорондох зөрүү нь гурван сараас илүүгүй байна; ба***



**(е) Адил төсөөтэй мөнгөн ажил гүйлгээний хувьд нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлого баримталснаар нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэнэ. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлого баримтлах практик боломжгүй бол нягтлан бодох бүртгэлийн өөр бодлого хэрэглэсэн зүйлсийн тухайн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь хувийн жингийн хамтаар ийм практик боломжгүй байдлын талаархи тодруулгыг хийнэ.**

1.6.17 1.6.16-р параграфт дурдсан, нэгтгэлийн горим нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх бүх байгууллагуудын нэгтгэсэн санхүүгийн тайланг эдийн засгийн нэг нэгж байдлаар бэлтгэх суурь үндэслэлээр хангах юм.

1.6.18 Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллага ба түүний хувьд гаднын байх бусад байгууллагуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээг зөвхөн тусгана. Иймээс тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээг давхар тооцохоос сэргийлэхийн тулд устгаж цэвэрлэдэг. Жишээлбэл; засгийн газрын нэг хэлтэс нь засгийн газрын өөр нэг хэлтэст биет хөрөнгийг борлуулж болох юм. Нийт засгийн газрын тайлагнагч байгууллагын хувьд цэвэр мөнгөн үр нөлөө нь тэг учраас уг нийт засгийн газрын тайлагнагч байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлагыг илүү илэрхийлэхээс зайлсхийхийн тулд энэхүү ажил гүйлгээг устгаж, цэвэрлэх шаардлагатай. Засгийн газар нь улсын секторын санхүүгийн байгууллагад мөнгө сангаа байршуулдаг байж болно. Ийм үлдэгдэл нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх үлдэгдлийг илэрхийлэх учраас нийт засгийн газрын түвшинд үүнийг устгаж цэвэрлэнэ. Үүнтэй адилаар, гадаадад үйл ажиллагаа явуулдаг УҮГ нь засгийн газарт төлбөр төлсөн бөгөөд энэ нь тухайн тайлангийн өдрөөр замд яваа мөнгө байж болох юм. Энэ тохиолдолд уг ажил гүйлгээг устгаж цэвэрлэхгүй байх нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын мөнгөний үлдэгдлийг дутуу, харин мөнгө зарлагыг илүү илэрхийлэхэд хүргэнэ.

1.6.19 Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх бие даасан байгууллагууд нь мөнгөн орлого, мөнгөн зарлагын ангилал болон өөрсдийн санхүүгийн тайлангийн толилуулгын хувьд өөр өөр бодлогуудыг мөрдөж болох юм. Ийм ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн орлого буюу мөнгөн зарлагыг хэрэв практик боломжтой бол нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгдмэл арга маягаар ангилж, толилуулна.

### **Нэгтгэлийн тодруулга**

1.6.20 ***Нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах тодруулгыг хийнэ:***

**(а) *Хяналтанд буй томоохон байгууллагуудын жагсаалт, үүн дотроо тухайн хяналтанд буй байгууллагын нэр ба үйл ажиллагаа явуулдаг улс орон (хяналт тавигч байгууллагын улс орноос өөр тохиолдолд); ба***

**(б) Хяналтанд буй байгууллагыг нэгтгээгүй шалтгаан.**

**Шилжилтийн нөхцлүүд**

1.6.21 Энэ Стандартыг мөрддөг хяналт тавигч байгууллага нь хоорондоо хийсэн маш их хэмжээний ажил гүйлгээ бүхий хяналтанд буй олон байгууллагуудтай байж болно. Иймээс эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх зорилгын хувьд устгах шаардлагатай бүх ажил гүйлгээ болон үлдэгдлүүдийг тогтооход төвөгтэй байж болох юм. Энэ шалтгааны улмаас эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох бүх мөнгөний үлдэгдэл болон ажил гүйлгээг устган цэвэрлэх шаардлагаас шилжилтийн хугацаанд чөлөөлөхөөр 1.8.2-р параграфт заасан. Гэвч шилжилтийн нөхцлийг мөрдөж буй байгууллагууд нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох бүх мөнгөний үлдэгдэл болон ажил гүйлгээг устгаж цэвэрлээгүй гэдгээ тодруулахыг 1.8.3-р параграфтаар шаардсан байдаг.

**1.7 Гадаад валют**

**Тодорхойлолт**

1.7.1 *Дараах нэр томъёог энэ Стандартад доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:*

*Хаалтын ханш гэдэг нь тайлангийн өдрийн спот ханш юм.*

*Ханшийн зөрүү гэдэг нь ижил тооны гадаад валютыг толилуулгын валютад өөр өөр ханшаар хөрвүүлснээс үүссэн зөрүү юм.*

*Валютын ханш гэдэг нь хоёр валютын хоорондох солилцооны харьцаа юм.*

*Гадаад валют гэдэг нь байгууллагын толилуулгын валютаас өөр валют юм.*

*Толилуулгын валют гэдэг нь тухайн санхүүгийн тайланг толилуулахад ашигладаг валют юм.*

**Гадаад валютаарх мөнгөн орлого, зарлага, үлдэгдлийн бүртгэлийн арга**

1.7.2 *Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн орлого, зарлагыг уг орлого, зарлага гарсан өдрийн толилуулгын валют болон гадаад валютын хоорондох ханшаар тэрхүү гадаад валютын дүнг үржүүлж, тухайн байгууллагын толилуулгын валютаар бүртгэнэ.*

1.7.3 *Гадаад валютаар эзэмшиж буй мөнгөний үлдэгдлийг хаалтын ханшийг ашиглан тайлагнана.*

- 1.7.4 ***Хяналтанд буй гадаад дахь байгууллагын мөнгөн орлого ба мөнгөн зарлагыг уг орлого, зарлага гарсан өдрийн толилуулгын валют болон гадаад валютын хоорондох ханшаар хөрвүүлнэ.***
- 1.7.5 ***Байгууллага нь тухайн тайлант үеийн мөнгөний эхний ба эцсийн үлдэгдлийн хоорондох тохируулгын зүйлс байдлаар тусган оруулсан ханшийн зөрүүгийн дүнг тодруулна.***
- 1.7.6 ***Толилуулгын валют нь тухайн байгууллагын оршин суугаа улсын валютаас өөр бол ийм өөр валют ашиглаж буй шалтгааныг тодруулна. Толилуулгын валютын аливаа өөрчлөлтийн шалтгааныг бас тодруулна.***
- 1.7.7 Засгийн газрууд болон засгийн газрын байгууллагууд нь гадаад валютын зээл авах эсвэл худалдан авалтын үнийг гадаад валютаар илэрхийлсэн бараа, үйлчилгээ худалдан авах гэх мэт гадаад валютын ажил гүйлгээ хийж болох юм. Тэд мөн гадаад үйл ажиллагаатай байж болох бөгөөд гадаад үйл ажиллагаандаа мөнгө шилжүүлж эсвэл хүлээн авч болно. Гадаад валютаарх ажил гүйлгээ болон гадаад үйл ажиллагааг санхүүгийн тайланд тусгахын тулд байгууллага нь мөнгөн орлого, зарлага болон үлдэгдлийг толилуулгын валютаар илэрхийлэх ёстой.
- 1.7.8 Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй олз, гарз нь мөнгөн орлого, зарлага биш юм. Гэвч тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх мөнгөний үлдэгдлийг тохируулахын тулд гадаад валютаар эзэмшиж буй мөнгөнд валютын ханшийн өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөөг мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнана. Энэхүү дүнг мөнгөн орлого, зарлагаас тусдаа толилуулах бөгөөд хэрэв тэдгээр мөнгөн орлого, зарлага болон үлдэгдлийг тайлант үеийн эцсийн ханшаар тайлагнасан бол үүсэх аливаа зөрүүг үүнд хамруулна.

## **1.8 Нэгдүгээр хэсгийн 1-7-р дэд хэсгүүдийн хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилтийн нөхцлүүд**

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

- 1.8.1 ***Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Нэгдүгээр хэсгийн 1-7 дугаар дэд хэсгүүд нь 2004 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд хүчин төгөлдөр үйлчилнэ. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг дэмжинэ.***

### **Шилжилтийн нөхцлүүд-Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

- 1.8.2 ***Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох мөнгөний үлдэгдэл болон ажил гүйлгээг устгаж цэвэрлэх талаархи 1.6.16(а) параграфын шаардлагыг байгууллагууд нь энэ Стандартыг анх мөрдсөн өдрөөс хойшхи гурван жилийн***

*дотор эхлэх тайлант үеүдийн хувьд даган мөрдөх шаардлагагүй юм.*

- 1.8.3 *Дээрх 1.8.2-р параграф дахь шилжилтийн нөхцлийг мөрдөж байгаа тохиолдолд байгууллагууд нь уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох бүх мөнгөний үлдэгдэл болон ажил гүйлгээг устгаж цэвэрлээгүй гэдгийг тодруулах хэрэгтэй.*

## **1.9 Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга**

### **Тодорхойлолт**

- 1.9.1 *Дараах нэр томъёог энэ Стандартад доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:*

Нягтлан бодох бүртгэлийн суурь гэдэг нь аккруэл суурьт УСНББОУС болон мөнгөн суурьт УСНББОУС-д тодорхойлсон нягтлан бодох бүртгэлийн аккруэл буюу мөнгөн суурь юм.

Жилийн төсөв гэдэг нь нэг жилийн хувьд батлагдсан төсөв юм. Тухайн төсвийн жилээс хойшхи тайлант үеүдийн хувьд хэвлэн нийтэлсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл нь үүнд хамаарахгүй.

Төсвийн хуваарилалт гэдэг нь хууль тогтоох буюу адилтгах эрх бүхий этгээдийн тусгайлан тодорхойлсон зорилгод зориулан мөнгө санг хуваарилахын тулд хууль тогтоогч байгууллагаас олгосон зөвшөөрөл юм.

Батлагдсан төсөв гэдэг нь хууль, төсвийн хуваарилалтын мэдэгдэл, засгийн газрын тогтоол болон тухайн төсвийн хугацааны урьдчилан төсөөлсөн орлого буюу мөнгөн орлоготой холбоотой бусад шийдвэрээр үүсэх зарлагын эрх юм.

Төсвийн суурь гэдэг нь хууль тогтоогч байгууллагаас баталсан тухайн төсөвт мөрддөг нягтлан бодох бүртгэлийн аккруэл, мөнгөн буюу бусад суурь юм.

Зэрэгцүүлэгдэх суурь гэдэг нь тухайн нэг байгууллагуудын хувьд уг батлагдсан төсөвтэй ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн суурь болон нэг ижил ангиллын сууриар толилуулсан гүйцэтгэлийн дүн юм.

Тодотгосон төсөв гэдэг нь тухайн төсвийн хугацаанд хамаарах бүх нөөц, өмнөх үеэс шилжиж ирсэн дүн, шилжүүлэг, хуваарилалт, нэмэлт төсвийн хуваарилалт болон бусад зөвшөөрөгдсөн хууль тогтоомжийн буюу адилтгах бүрэн эрхийн дагуу хийгдсэн өөрчлөлтийн хувьд тохируулга хийсэн анхны төсөв юм.

Олон-жилийн төсөв гэдэг нь нэгээс олон жилийн хувьд батлагдсан төсөв юм. Тухайн төсвийн хугацаанаас хойшхи тайлант үеүдийн

***хувьд хэвлэн нийтэлсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл нь үүнд хамаарахгүй.***

**Анхны төсөв гэдэг нь тухайн төсвийн хугацааны хувьд анх батлагдсан төсөв юм.**

#### **Батлагдсан төсөв**

- 1.9.2 Энэ Стандартад тодорхойлсончлон, батлагдсан төсөв нь одоогийн төлөвлөгөө болон тухайн төсвийн хугацааны туршид урьдчилан төсөөлсөн эдийн засгийн нөхцөл байдал, хууль тогтоох эсвэл бусад холбогдох бүрэн эрх бүхий хууль тогтоогч байгууллагын баталсан зардал буюу зарлагад үндэслэн тэрхүү жилийн эсвэл олон жилийн төсвийн хугацаанд үүсэхээр хүлээгдэж буй урьдчилан төсөөлсөн орлого буюу мөнгөн орлогыг тусгадаг. Батлагдсан төсөв нь гарч тохиолдохоор заавал хүлээгдээгүй ирээдүйн үйл явдлууд болон удирдлагын боломжит үйлдлийн талаархи таамаглалд үндэслэсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл биш юм. Үүнтэй адилаар, батлагдсан төсөв нь прогноз, төсөөлөл эсвэл эдгээрийн хослол, жишээлбэл; нэг жилийн прогноз ба таван жилийн төсөөлөл хэлбэртэй байх хэтийн санхүүгийн мэдээллээс ялгаатай юм.
- 1.9.3 Зарим улс оронд, төсвийг батлах үйл явцын нэгэн хэсэг байдлаар тухайн төсвийг хуульчлан баталдаг байж болно. Өөр зарим улс оронд, төсвийг хууль болгохгүйгээр баталдаг байж болох юм. Батлах үйл явц ямар байхаас үл хамааран тухайн батлагдсан төсвийн гол шинж нь тохиролцсон ба тогтоосон зорилгод зориулан засгийн газрын төрийн сан буюу адилтгах байгууллагаас мөнгө санг татан авах эрхийг хууль тогтоогч дээд түвшний байгууллага буюу зохих эрх бүхий бусад байгууллагаас олгох явдал юм. Батлагдсан төсөв нь тусгайлан заасан зүйлсийн хувьд зарлагын эрхийг тогтоодог. Зарлагын эрхийг ерөнхийдөө хууль ёсны хязгаар гэж үздэг бөгөөд байгууллага нь энэхүү хүрээнд үйл ажиллагаагаа явуулах ёстой. Зарим улс орны хувьд, тухайн байгууллагад хариуцуулах батлагдсан төсөв нь анхны төсөв байж болно, харин өөр зарим улс оронд тодотгосон төсөв байж болох юм.
- 1.9.4 Төсвийн хугацаа эхлэхээс өмнө төсвийг батлаагүй бол анхны төсөв нь тухайн төсвийн жилд мөрдөхөөр анх баталсан төсөв байдаг.

#### **Анхны болон тодотгосон төсөв**

- 1.9.5 Анхны төсөв нь өмнөх жилүүдээс хуулийн дагуу автоматаар шилжиж ирсэн, төсвийн хуваарилалтын зарцуулагдаагүй үлдэгдлийг агуулсан байж болно. Жишээлбэл; зарим улс оронд засгийн газрын төсөвлөлтийн үйл явц нь өмнөх жилийн амлалтыг биелүүлэхийн тулд өмнөх төсвийн хуваарилалтыг автоматаар дараагийн жилд шилжүүлэхийг шаардсан хуулийн заалттай байдаг. Амлалт нь одоогийн гэрээ хэлцэлд үндэслэсэн ирээдүйн боломжит өр төлбөрийг агуулдаг. Зарим улс оронд амлалтыг үүрэг эсвэл хариуцлага гэж нэрлэдэг бөгөөд бараа, үйлчилгээг хараахан хүлээн аваагүй байх үеийн биелэгдээгүй худалдан авалтын захиалга ба гэрээ нь үүнд хамаардаг.

- 1.9.6 Анхны төсөв нь тухайлбал, дайн байлдаан буюу байгалийн гамшгаас үүдэлтэй зарлагын хэрэгцээ шаардлагуудыг зохих ёсоор хангаж чадахгүй тохиолдолд нэмэлт төсвийн хуваарилалт шаардлагатай байж болох юм. Түүнчлэн, тайлант үеийн төсөвлөсөн орлого тасалдах ба тухайн төсвийн жилийн туршид санхүүжилтийн тэргүүн ээлжийн эрхийг өөрчлөхийн тулд төсвийн бүрэлдэхүүн хооронд эсвэл төсвийн мөрийн зүйлс хооронд дотоод шилжүүлэлт хийх шаардлагатай байж болно. Иймээс төсвийн сахилга батыг хангахын тулд тухайн тайлант үед анх хуваарилсан дүнгээс уг байгууллагад буюу үйл ажиллагаанд хуваарилсан мөнгө санг буцаан багасгах шаардлагатай байж болох юм. Тодотгосон төсөв нь ийм зөвшөөрөгдсөн бүх өөрчлөлт буюу нэмэлт өөрчлөлтийг тусгасан байдаг.

#### **Гүйцэтгэлийн дүн**

- 1.9.7 Төсвийн хэрэгжилтийн үр дүн болох дүнгүүдийг илэрхийлэхийн тулд энэ Стандартад гүйцэтгэл буюу гүйцэтгэлийн дүн гэсэн нэр томъёог ашигласан. Зарим улс оронд, төсвийн төлөвлөгөөний биелэлт, төсвийн хэрэгжилт болон адилтгах нэр томъёог гүйцэтгэл буюу гүйцэтгэлийн дүн гэдэгтэй ижил утгатайгаар ашигладаг байж болох юм.

#### **Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлсэн толилуулга**

- 1.9.8 *1.9.17-р параграфт шаардсанаас бусад тохиолдолд, батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллага нь олон нийтийн өмнө хариуцах төсвийн дүн ба гүйцэтгэлийн дүн хоорондох зэрэгцүүлэлтийг тусад нь нэмэлт санхүүгийн тайлан байдлаар эсвэл энэхүү Стандартын дагуу одоо толилуулж буй мөнгөн орлого, зарлагын тайлан дахь төсвийн нэмэлт багана хэлбэрээр толилуулна. Хууль тогтоомжийн хяналтын түвшин бүрийн хувьд төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусад нь толилуулна:*
- (a) *Анхны болон тодотгосон төсвийн дүнгүүд;*
  - (б) *Зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүнгүүд; ба*
  - (в) *Олон нийтийн өмнө тухайн байгууллагын хариуцдаг төсөв болон гүйцэтгэлийн дүнгийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг уг санхүүгийн тайлангийн хамтаар гаргаж, олон нийтэд танилцуулдаг бусад баримт бичигт тусган оруулдаг бөгөөд тэдгээр баримт бичигт харилцан лавлагаа үүсгэж, санхүүгийн тайлангийн тодруулгад харуулдагаас бусад тохиолдолд тэмдэглэл тодруулга хэлбэрээр хийх ийм тайлбар.*

#### **Цар хүрээ**

- 1.9.9 Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай буюу тийм сонголт хийсэн бүх байгууллагуудад энэ Стандартыг мөрдөнө. Энэ Стандарт нь батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулахыг

шаардахгүй, мөн олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй, тийм батлагдсан төсвийн талаар санхүүгийн тайлангийн тодруулгын мэдээлэл бэлтгэх буюу төсөвтэй зэрэгцүүлэхийг шаардахгүй.

- 1.9.10 Батлагдсан төсөв нь улсын секторын хяналтанд буй бүх үйл ажиллагааг хамрах байдлаар зарим тохиолдолд зохиогдсон байдаг. Өөр зарим тохилдолд, засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын санхүүгийн тайланд тусгасан тодорхой үйл ажиллагаа, бүлэг үйл ажиллагаа буюу байгууллагуудын хувьд тусдаа батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулах шаардлагатай байж болох юм. Тухайлбал; засгийн газрын санхүүгийн тайлан нь үйл ажиллагааны хувьд хараат бус бөгөөд өөрсдийн төсвийг бэлтгэдэг тийм засгийн газрын агентлагууд буюу хөтөлбөрүүдийг агуулдаг, эсвэл нийт засгийн газрын зөвхөн үндсэн секторын хувьд төсвийг бэлтгэдэг бол ийм тохиолдол үүсэж болно. Тухайн байгууллагын хувьд батлагдсан төсөв буюу түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг олон нийтэд нээлттэй танилцуулах үедээ санхүүгийн тайлангаа толилуулдаг бүх байгууллагуудын хувьд энэ Стандартыг мөрдөнө.

#### **Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт**

- 1.9.11 Анхны болон тодотгосон төсвийн дүнгүүд, түүнчлэн олон нийтэд нээлттэй танилцуулдаг төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар харуулсан гүйцэтгэлийн дүнгүүдийн санхүүгийн тайлан дахь толилуулга нь нөөцийг уг батлагдсан төсвийн дагуу олж авч, ашиглан зарцуулсан эсэхийг тодорхойлох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгосноор тухайн хариуцлагын циклийг иж бүрэн болгодог. Анхны эсвэл тодотгосон төсөв гэдгээс үл хамааран төсвийн болон гүйцэтгэлийн дүн хоорондох зөрүүг (нягтлан бодох бүртгэлд ихэвчлэн “хэлбэлзэл” гэж нэрлэдэг) иж бүрэн байдлын зорилгоор санхүүгийн тайланд мөн толилуулж болох юм.
- 1.9.12 Гүйцэтгэлийн дүн ба төсвийн дүнгийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбар нь олон нийтийн өмнө тухайн байгууллагын хариуцах уг батлагдсан төсвөөс материаллагаар гажсан шалтгааныг ойлгоход хэрэглэгчдэд тусална.
- 1.9.13 Байгууллага нь өөрийн анхны төсөв, тодотгосон төсөв эсвэл эдгээрийн аль алиныг олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай буюу ингэж танилцуулах сонголт хийж болох юм. Анхны болон тодотгосон төсвийн аль алиныг олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай тохиолдолд уг анхны төсвийн дүн ба гүйцэтгэлийн дүн хоорондох, эсвэл тодотгосон төсөв ба түүний гүйцэтгэлийн дүн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг 1.9.8(в) параграфын дагуу хийх шаардлагатай эсэх талаархи заавар удирдамжийг ихэвчлэн хууль тогтоомж, зохицуулалт буюу бусад эрх бүхий баримт бичигт заасан байдаг. Ийм аливаа заавар удирдамж байхгүй тохиолдолд жишээлбэл, анхны төсөвтэй гүйцэтгэлийг харьцуулахад голлон анхаарахын тулд тэрхүү анхны төсөв ба гүйцэтгэлийн дүн хоорондох зөрүүг, эсвэл тодотгосон төсвийн даган мөрдөлтөнд голлон анхаарахын тулд тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн дүн хоорондох зөрүүг лавлагаа болгосноор уг материаллаг зөрүүг тодорхойлж болох юм.

- 1.9.14 Тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн дүн нь олон тохиолдолд ижил байдаг. Яагаад гэвэл, төсвийн хэрэгжилтийг тайлант үеийн туршид хянан үнэлдэг бөгөөд тухайн тайлант үед өөрчлөгдөж буй нөхцөл, өөрчлөгдөж буй төлөв байдал болон туршлагыг тусгахын тулд анхны төсвийг явцын дунд хянан засварладаг. Анхны болон тодотгосон төсөв хоорондох өөрчлөлтийн шалтгааны талаархи тайлбарын хувьд тодруулга хийхийг энэ Стандартын 1.9.23-р параграфтаар шаардсан байдаг. Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллагууд нь өөрсдийн гүйцэтгэлийг тэдгээр холбогдох батлагдсан төсөвтэй харьцуулж, түүнтэй нийцсэн байдлаар олон нийтэд нээлттэй танилцуулдаг эсэхийг эдгээр тодруулга болон дээрх 1.9.8-р параграфтаар шаардсан тодруулга нь харуулна.
- 1.9.15 Тайлант үеийн турш дахь уг байгууллагын гүйцэтгэл ба ололт амжилтын талаархи санал мэдэгдэл, үүн дотроо төсвийн дүнгээс гажсан аливаа материаллаг зөрүүгийн тайлбараар хангадаг удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ, үйл ажиллагааны тойм мэдээ буюу олон нийтэд танилцуулдаг бусад тайланг ихэвчлэн тухайн санхүүгийн тайлантай хамт гаргадаг. Энэ Стандартын 1.9.8(в) параграфт заасанчлан, гүйцэтгэлийн болон төсвийн дүнгүүдийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг тухайн санхүүгийн тайлангийн хамт гаргаж, олон нийтэд танилцуулдаг бусад тайлан буюу баримт бичигт тусган оруулдаг бөгөөд ийм тайлбарыг хийсэн тайлан буюу баримт бичгийг уг санхүүгийн тайланд тодруулдаг байхаас бусад тохиолдолд түүнийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусган харуулна.
- 1.9.16 Санхүүгийн тайланд тусган оруулсан зөвхөн зарим байгууллага буюу үйл ажиллагааны хувьд тухайн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаг тохиолдолд тэрхүү батлагдсан төсөвт тусгасан зөвхөн тэдгээр байгууллага буюу үйл ажиллагаанд 1.9.8-р параграфын шаардлагуудыг даган мөрдөнө. Энэ нь тухайлбал, тайлагнагч байгууллага болох нийт засгийн газрын зөвхөн үндсэн секторын хувьд төсвийг бэлтгэдэг бол 1.9.8-р параграфтаар шаардсан тодруулгыг тухайн засгийн газрын зөвхөн үндсэн секторын хувьд хийнэ гэсэн үг юм.

### Толилуулга

- 1.9.17 ***Санхүүгийн тайлан ба төсвийг зөвхөн зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэг тохиолдолд байгууллага нь төсвийн дүн болон гүйцэтгэлийн дүн хоорондох зэрэгцүүлэлтийг мөнгөн орлого, зарлагын тайланд төсвийн нэмэлт багана оруулах байдлаар толилуулна.***
- 1.9.18 Төсвийн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусдаа санхүүгийн тайлан (“төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайлан” буюу үүнтэй адилтгах нэршил бүхий тайлан)-д толилуулж болно. Өөр нэг хувилбар бол, санхүүгийн тайлан болон төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар, өөрөөр хэлбэл тухайн нэг байгууллагын хувьд ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн сууриар бэлтгэдэг бөгөөд нэг ижил ангиллын бүтцийг мөрддөг тохиолдолд энэхүү Стандартын дагуу



толилуулсан мөнгөн орлого, зарлагын тайланд нэмэлт багана оруулж болох юм. Анхны ба тодотгосон төсвийн дүн, түүнчлэн тухайн байгууллага хүсвэл уг төсвийн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох зөрүүг эдгээр нэмэлт багананд тусган харуулдаг.

- 1.9.19 Төсөв ба санхүүгийн тайланг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэггүй тохиолдолд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайланг тусад нь толилуулна. Ийм тохиолдолд өөр өөр сууриудаар бэлтгэсэн санхүүгийн мэдээллийг хэрэглэгч нар буруу ойлгохоос сэргийлэхийн тулд төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн сууриуд ялгаатай бөгөөд Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайланг төсвийн сууриар бэлтгэсэн гэдгийг санхүүгийн тайланд зохих ёсоор тодруулж болох юм.

### **Нэгтгэлийн түвшин**

- 1.9.20 Төсвийн баримт бичиг нь тодорхой үйл ажиллагаа, хөтөлбөр буюу байгууллагын талаархи маш дэлгэрэнгүй мэдээллээр хангаж болох юм. Эдгээр дэлгэрэнгүй мэдээллийг тухайн төсвийн үндсэн бүрэлдэхүүний дагуу ерөнхий ангиуд, төсвийн ангилал эсвэл хууль тогтоогч болон бусад эрх бүхий байгууллагад толилуулах ба тэднээр батлуулахад зориулсан төсвийн бүрэлдэхүүнээр ихэвчлэн нэгтгэдэг. Эдгээр ерөнхий ангиуд ба төсвийн бүрэлдэхүүнтэй нийцсэн төсвийн болон гүйцэтгэлийн мэдээллийн тодруулга нь уг төсвийн баримт бичигт тодорхойлсон, хууль тогтоох буюу бусад эрх бүхий байгууллагуудын хяналтын түвшнээр зэрэгцүүлэлтийг хийх боломж бүрдүүлдэг.
- 1.9.21 Зарим тохиолдолд, батлагдсан төсөвт тусгасан уг дэлгэрэнгүй санхүүгийн мэдээллийг энэ Стандартын шаардлагуудын дагуу санхүүгийн тайланд толилуулахын тулд нэгтгэх шаардлагатай байж болох юм. Мэдээллийн хэт ачаалал үүсгэхээс зайлсхийх ба хууль тогтоох буюу бусад эрх бүхий байгууллагуудын хяналтын холбогдох түвшинг тусгахад ийм нэгтгэл зайлшгүй шаардлагатай байж болно. Нэгтгэлийн түвшинг тодорхойлохдоо мэргэжлийн шүүн тунгаалт хийдэг. Энэ Стандартын зорилгын агуулга болон мөн уг Стандартын 1.3.32-р параграфт дурдсан, санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг харгалзан ийм шүүн тунгаалтыг хийнэ.
- 1.9.22 Төсвийн нэмэлт мэдээлэл, үүн дотроо үйлчилгээний үр дүнгийн талаархи мэдээллийг санхүүгийн тайлангаас өөр бусад баримт бичигт толилуулж болох юм. Санхүүгийн тайлангаас ийм баримт бичгүүдэд харилцан лавлагаа үүсгэхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн байдаг.

### **Анхны төсвөөс тодотгосон төсөв болгох өөрчлөлт**

- 1.9.23 *Анхны төсөв ба тодотгосон төсвийн хоорондох өөрчлөлт нь тухайн төсвийн доторх дахин хуваарилалтын эсвэл бусад хүчин зүйлсийн үр дагавар эсэх талаархи тайлбарыг байгууллага нь дараах байдлаар толилуулна:*

- (а) **Санхүүгийн тайлан дахь тэмдэглэл тодруулга байдлаар; эсвэл**
- (б) **Санхүүгийн тайланг гаргахаас өмнө, гаргах үед эсвэл түүнтэй хамт гаргасан тайлан илтгэлд оруулах ба тэрхүү тайланд үүсгэсэн харилцан лавлагааг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад тусгах.**

1.9.24 Тодотгосон төсөв нь анхны төсвийг хянан засварлах хууль ёсны ажиллагаа буюу бусад олгогдсон бүрэн эрхийн дагуу баталсан бүх өөрчлөлтүүдийг агуулсан байдаг. Энэ Стандартын шаардлагуудын дагуу, анхны төсөв ба тодотгосон төсвийн хоорондох өөрчлөлтийн талаархи тайлбарыг санхүүгийн тайлангийн тодруулгад эсвэл тухайн санхүүгийн тайланг гаргахаас өмнө, гаргах үед эсвэл түүнтэй хамт гаргасан тусдаа тайлан илтгэлд тусгана. Өөрчлөлт нь тухайлбал, анхны төсвийн параметруудийн хүрээнд дахин хуваарилалт хийсний үр дүнд, эсвэл төсвийн ерөнхий параметруудийн өөрчлөлт, үүн дотроо засгийн газрын бодлогын өөрчлөлт гэх мэт бусад хүчин зүйлсийн үр дүнд үүссэн эсэхийг уг тайлбарт тусгана. Санхүүгийн тайлангийн нэг хэсэг байдлаар биш боловч түүнтэй хамт гаргасан удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ буюу үйл ажиллагааны талаархи адилтгах тайланд ийм тодруулгыг ихэвчлэн хийдэг. Төсвийн хэрэгжилтийг тайлагнахын тулд засгийн газраас гаргасан төсвийн үр дүнгийн тайланд ийм тодруулгыг бас хийж болно. Тодруулгыг санхүүгийн тайланд бус, харин тусдаа тайланд хийсэн тохиолдолд уг тайлантай холбосон харилцан лавлагааг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад харуулна.

### **Зэрэгцүүлэгдэх суурь**

- 1.9.25 **Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох бүх зэрэгцүүлэлтийг тухайн төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар толилуулна.**
- 1.9.26 Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг тухайн нэг байгууллагуудын хувьд уг батлагдсан төсөвтэй ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн суурь (аккруэл, мөнгөн буюу бусад суурь) болон нэг ижил ангиллын сууриар толилуулна. Төсвийн даган мөрдөлтийн талаархи санхүүгийн тайлан дахь мэдээллийн тодруулга нь уг төсөвтэй ижил сууриар хийгдсэн гэдгийг энэ нь ханган магадалдаг. Энэ нь төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлэлтийг янз бүрийн бүлэг үйл ажиллагааны хувьд нягтлан бодох бүртгэлийн өөр сууриар болон тухайн санхүүгийн тайланд мөрдсөнөөс ялгаатай, толилуулгын буюу ангиллын хэв загвараар зарим тохиолдолд толилуулдаг гэсэн утгыг илэрхийлж болох юм.
- 1.9.27 Санхүүгийн тайлан нь тухайн байгууллагын хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааг нэгтгэн тусгадаг. 1.9.10-р параграфт дурдсанчлан, тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланг бүрдүүлж буй бие даасан байгууллагууд буюу тодорхой үйл ажиллагаануудын хувьд тусдаа төсөв баталж, олон нийтэд нээлттэй танилцуулж болох юм. Ингэж тусдаа төсөв бэлтгэдэг тохиолдолд энэхүү Стандартын шаардлагуудын дагуу тухайн санхүүгийн тайланд толилуулах зорилгоор тэдгээр тусдаа төсвүүдийг

дахин нэгтгэн бүрдүүлж болно. Ийм дахин нэгтгэн бүрдүүлэлтийг хийх үедээ уг батлагдсан төсвийн өөрчлөлт буюу хянан засварлалтыг түүнд тусгадаггүй. Яагаад гэвэл, энэ Стандарт нь гүйцэтгэлийн дүнг уг батлагдсан төсвийн дүнтэй зэрэгцүүлэхийг шаарддаг.

- 1.9.28 Байгууллагууд нь өөрсдийн санхүүгийн тайлангийн бэлтгэлт болон батлагдсан төсөвтөө нягтлан бодох бүртгэлийн өөр өөр сууриудыг мөрдөж болох юм. Жишээлбэл; цөөн боловч зарим тохиолдолд засгийн газар буюу засгийн газрын агентлаг нь өөрийн санхүүгийн тайландаа мөнгөн суурийг, төсөвтөө аккруэл суурийг мөрдөж болно. Мөн түүнчлэн, санхүүгийн тайланд мөнгөн орлого, мөнгөн зарлага болон үлдэгдлийг тайлагнадаг боловч төсөв нь ирээдүйд мөнгө санг зарцуулах амлалтууд ба тэдгээр амлалтын өөрчлөлтүүдийн талаархи мэдээлэлд голлон чиглэх буюу түүнийг агуулсан байж болно. Гэхдээ төсөв бэлтгэж буй байгууллага болон санхүүгийн тайлагналын байгууллага нь ихэвчлэн нэг ижил байгууллага байдаг. Үүнтэй адилаар, төсвийг бэлтгэсэн хугацаа болон тухайн төсөвт мөрдсөн ангиллын суурийг санхүүгийн тайланд ихэвчлэн тусгадаг. Энэ нь тухайлбал, уг төсвийн хугацааны туршид төсвийн хэрэгжилтийн явцыг хянан удирдах, түүнчлэн засгийн газар, олон нийт ба бусад хэрэглэгчдэд зохих ёсоор, цаг хугацаанд нь тайлагнах удирдлагын болон хариуцлагын зорилгоор төсөв ба гүйцэтгэлийн мэдээний зэрэгцүүлэлт хийх боломжтой байдлаар санхүүгийн мэдээллийг тухайн нягтлан бодох бүртгэлийн систем бэлтгэж, тайлагнаж байгаа гэдгийг ханган магадалдаг.
- 1.9.29 Тухайн санхүүгийн тайланд тусгагдсан байгууллага, үйл ажиллагаанаас өөр байгууллагууд болон үйл ажиллагаануудыг агуулдаг статистикийн тайлагналын системтэй нийцсэн мөнгөн эсвэл аккруэл сууриар зарим улс оронд төсвийг бэлтгэж болох юм. Жишээлбэл; санхүүгийн тайлан нь засгийн газрын хянадаг бүх үйл ажиллагаанууд, үүн дотроо тухайн засгийн газрын бизнесийн үйл ажиллагааны талаар тайлагнадаг бол статистикийн тайлагналын системд нийцүүлэн бэлтгэсэн төсөв нь засгийн газрын үндсэн секторт голлон чиглэдэг бөгөөд өөрийн үндсэн үйл ажиллагаа байдлаар засгийн газрын “анхдагч” буюу “зах зээлийн бус” чиг үүргийг зөвхөн биелүүлдэг байгууллагуудыг хамарсан байж болох юм.
- 1.9.30 Статистикийн тайлагналын загварын хувьд засгийн газрын үндсэн сектор нь үндэсний, мужийн/бүсийн болон орон нутгийн засгийн газрын түвшингүүдээс бүрдэж болох юм. Зарим улс орны хувьд, үндэсний засгийн газар нь мужийн/бүсийн болон орон нутгийн засгийн газруудыг хянаж, тэдгээр засгийн газруудыг өөрийн санхүүгийн тайландаа нэгтгэдэг бөгөөд засгийн газрын эдгээр бүх гурван түвшинг агуулдаг уг батлагдсан төсвийг боловсруулж, олон нийтэд нээлттэй танилцуулахыг шаарддаг байж болно. Ийм тохиолдолд, үндэсний засгийн газрын тэдгээр байгууллагуудын санхүүгийн тайланд энэхүү Стандартын шаардлагуудыг мөрдөнө. Гэвч үндэсний засгийн газар нь мужийн/бүсийн буюу орон нутгийн засгийн газруудыг хянадаггүй тохиолдолд түүний санхүүгийн тайланд мужийн/бүсийн буюу орон нутгийн засгийн газруудыг нэгтгэхгүй. Харин засгийн газрын түвшин тус бүрийн хувьд тусдаа санхүүгийн тайланг бэлтгэдэг. Засгийн газрын байгууллагын хянадаг байгууллагууд болон үйл

ажиллагаанууд эсвэл тэдгээрийн дэд хэсгүүдийн хувьд батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаг зөвхөн тийм тохиолдолд уг засгийн газрын байгууллагын санхүүгийн тайланд энэхүү Стандартын шаардлагуудыг мөрдөнө.

### **Олон жилийн төсөв**

- 1.9.31 Зарим засгийн газар болон бусад байгууллагууд нь тусдаа жилийн төсвийг биш, харин олон жилийн төсвийг бэлтгэж, олон нийтэд нээлттэй танилцуулдаг. Уламжлал ёсоор, олон жилийн төсөв нь хэд хэдэн жилийн төсөв буюу жилийн төсвийн зорилтуудаас бүрддэг. Бүрэлдэхүүн хэсэг болох жилийн тайлант үе бүрийн хувьд батлагдсан төсөв нь уг олон жилийн төсөвтэй холбоотой төсөвлөлтийн бодлогыг тэрхүү бүрэлдэхүүн тайлант үед хэрхэн мөрдөхийг тусгадаг. Зарим тохиолдолд, олон жилийн төсөв нь аливаа нэг жилийн хувьд ашиглагдаагүй төсвийн хуваарилалтын дараагийн жилүүд дэх шилжүүлэлтийг харуулдаг.
- 1.9.32 Олон жилийн төсөв бүхий засгийн газар ба бусад байгууллагууд нь төсвөө хэрхэн баталдагаас хамааран өөрсдийн анхны болон тодотгосон төсвөө тодорхойлохдоо янз бүрийн арга хандлагуудыг ашиглаж болох юм. Жишээлбэл; засгийн газар нь хоёр жилийн төсвийг агуулсан хоёр тайлант жилийн төсвийг баталж болох бөгөөд энэ тохиолдолд жил тус бүрийн батлагдсан анхны болон тодотгосон төсвийг тодорхойлох боломжтой байдаг. Хэрэв хоёр жилийн төсвийн эхний жилийн ашиглагдаагүй үлдсэн төсвийн хуваарилалтыг хоёр дахь жилд зарцуулахыг хууль ёсоор зөвшөөрдөг бол энэхүү өмнөх жилээс “шилжиж ирсэн” дүнгээр уг хоёр дахь жилийн “анхны” төсвийг нэмэгдүүлнэ. Засгийн газар нь жил тус бүрд хамаарах төсвийн дүнг тусгайлан салган харуулаагүй хоёр буюу бусад олон жилийн төсвийг баталдаг цөөн ховор тохиолдолд энэ Стандартын зорилгоор жилийн төсвийг тодорхойлохдоо, жил тус бүрд аль дүнгүүд хамаарахыг тогтоохын тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байж болох юм. Жишээлбэл; хоёр жилийн төсвийн эхний жилийн хувьд батлагдсан анхны болон тодотгосон төсөв нь эхний жилийн туршид хийгдэх уг хоёр жилийн аливаа батлагдсан капитал худалдан авалт, түүнчлэн тухайн жилд хамааруулж болох дахин давтагдах орлого ба зарлагын зүйлсийн дүнг агуулсан байдаг. Эхний жилээс зарцуулагдаагүй үлдсэн аливаа дүнг дараа нь хоёр дахь жилийн “анхны” төсөвт оруулах бөгөөд түүний аливаа нэмэлт өөрчлөлтийн хамтаар тухайн төсөв нь тэрхүү хоёр дахь жилийн тодотгосон төсөв болох юм. Тухайн төсвийн жилийн турш дахь төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох уялдаа холбооны талаар тодруулга хийхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн байдаг.

### **Төсвийн суурь, хугацаа, цар хүрээний тэмдэглэл тодруулга**

- 1.9.33 ***Байгууллага нь уг батлагдсан төсөвт хэрэглэсэн төсөвлөлтийн суурь болон ангиллын суурийг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тайлбарлана.***

- 1.9.34 Төсвийг бэлтгэж, толилуулахад ашигласан нягтлан бодох бүртгэлийн суурь (мөнгөн, аккрузал буюу тэдгээрийн зарим сайжруулалт) ба санхүүгийн тайланд ашигласан нягтлан бодох бүртгэлийн суурь нь өөр өөр байж болох юм. Нягтлан бодох бүртгэлийн систем ба төсвийн систем нь мэдээллийг өөр өөр төлөв байдлаас бэлтгэж бүрдүүлдэг тохиолдолд ийм зөрүү үүсэж болно. Тухайлбал; санхүүгийн тайлан нь мөнгөн орлого, мөнгөн зарлагыг тайлагнадаг бол төсөв нь мөнгөн гүйлгээ, түүнчлэн зарим хуримтлуулалт болон амлалтанд голлон чиглэдэг байж болно.
- 1.9.35 Батлагдсан төсвийг толилуулахад хэрэглэсэн хэлбэр болон ангиллын бүтэц нь санхүүгийн тайланд хэрэглэсэн хэлбэр, загвараас мөн өөр байж болно. Батлагдсан төсөв нь санхүүгийн тайланд хэрэглэсэнтэй ижил сууриар зүйлсийг тухайлбал, эдийн засгийн мөн чанараар (ажиллагчдын цалин хөлс, хангамжийн болон хэрэглээний зүйлс, буцалтгүй тусламж, шилжүүлэг гэх мэт) эсвэл чиг үүргээр (эрүүл мэнд, боловсрол гэх мэт) зарлагыг ангилж болох юм. Өөр нэг хувилбар бол, төсөв нь тусгай хөтөлбөрөөр (жишээлбэл; ядуурлыг бууруулалт, халдварт өвчний хяналт) эсвэл гүйцэтгэлийн үр дүнгийн зорилтуудтай холбоотой хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдээр (жишээлбэл; дээд боловсролын хөтөлбөрийг төгсөгч оюутнуудаар эсвэл эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээгээр хийсэн мэс заслын үйл ажиллагаагаар) зүйлсийг ангилж болох бөгөөд энэ нь санхүүгийн тайланд хэрэглэсэн ангиллаас өөр байдаг. Түүнчлэн, тасралтгүй үйл ажиллагааны (жишээлбэл; боловсрол буюу эрүүл мэнд) дахин давтагдах төсвийг капитал зарлагад (жишээлбэл; дэд бүтэц буюу барилга байгууламж)-д зориулсан капитал төсвөөс тусад нь баталж болох юм.
- 1.9.36 Батлагдсан төсвийг бэлтгэж, толилуулахад мөрдсөн төсөвлөлтийн суурь ба ангиллын суурийн талаархи тодруулга нь уг санхүүгийн тайланд тодруулсан төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн хоорондох уялдаа холбоог илүү сайн ойлгоход хэрэглэгчдэд тусалдаг.
- 1.9.37 ***Байгууллага нь уг батлагдсан төсвийн тайлант хугацааг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад тусгаж тодруулна.***
- 1.9.38 Санхүүгийн тайланг наад зах нь жил бүр бэлтгэж толилуулна. Байгууллагууд нь төсвийг жилээр эсвэл олон жилээр бэлтгэн баталж болох юм. Батлагдсан төсөвт хамаарах тайлант хугацаа нь санхүүгийн тайланд хэрэглэсэн тайлант хугацаанаас өөр байх тохиолдолд тэрхүү тайлант хугацааны талаархи тодруулга нь санхүүгийн тайлантай уг төсвийн мэдээ болон төсвийн зэрэгцүүлэлтийн холбогдох уялдаа холбоог тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар илүү сайн ойлгоход тусалдаг. Батлагдсан төсөвт хамаарах тайлант хугацаа нь санхүүгийн тайланд хамрагдах тайлант хугацаатай ижил байх тохиолдолд тэрхүү тайлант хугацааны талаархи тодруулга нь ялангуяа завсрын хугацааны төсөв, санхүүгийн тайлан болон бусад тайлан илтгэлийг бас бэлтгэдэг улс орнуудын хувьд мөн баталгаажуулах чухал үүргийг гүйцэтгэдэг.

- 1.9.39 ***Байгууллага нь уг батлагдсан төсөвт хамаарах байгууллагуудыг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад тусган тодорхойлно.***
- 1.9.40 Хяналт тавигч байгууллагууд нь тухайн засгийн газрын хянаж буй төсвөөс хамааралтай байгууллагууд болон УҮГ-уудыг агуулсан тийм нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахыг энэ Стандартын 1.6.5-р параграфтаар шаарддаг. Гэвч 1.9.29-р параграфт тэмдэглэсэнчлэн, статистикийн тайлагналын загварын дагуу бэлтгэдэг, батлагдсан төсөв нь худалдаа арилжааны буюу зах зээлийн сууриар хийгддэг тухайн засгийн газрын үйл ажиллагаануудыг хамруулан тусгаагүй байж болох юм. 1.9.25-р параграфын шаардлагуудын дагуу төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийг зэрэгцүүлэгдэх сууриар толилуулна. Төсөвт багтан хамрагдсан байгууллагуудын талаархи тодруулга нь тухайн байгууллагын үйл ажиллагаа тэрхүү батлагдсан төсөвт хамаарах хэмжээ, түүнчлэн тус төсөвт байгууллага нь уг санхүүгийн тайланд тусгагдсан байгууллагаас ямар ялгаатайг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог.

### **Зэрэгцүүлэгдэх сууриар тусгасан гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайлан дахь гүйцэтгэлийн дүнгийн хоорондох тохируулга**

- 1.9.41 ***Санхүүгийн тайлан ба төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэггүй тохиолдолд 1.9.25-р параграфын дагуу төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар толилуулсан гүйцэтгэлийн дүнг нийт мөнгөн орлого ба нийт мөнгөн зарлагатай тохируулж, аливаа суурь, цаг хугацаа болон байгууллагын зөрүүтэй байдлыг тусад нь тодорхойлно. Уг тохируулгыг төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайланд эсвэл санхүүгийн тайлангийн тэмдэглэлд хэсэгт тодруулж тусгана.***
- 1.9.42 Зэрэгцүүлэгдэх суурьтай нийцүүлэн тодорхойлсон гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн гүйцэтгэлийн дүнгийн хоорондох зөрүүг дараах байдлаар зохих ёсоор ангилж болно:
- (а) Төсөвлөлтийн суурийн зөрүү, энэ нь уг батлагдсан төсвийг нягтлан бодох бүртгэлийн сууриас өөр сууриар бэлтгэсэн үед үүсдэг. Жишээлбэл; төсвийг аккруэл сууриар эсвэл тохируулсан мөнгөн сууриар бэлтгэдэг, харин санхүүгийн тайланг мөнгөн сууриар бэлтгэдэг байх;
  - (б) Цаг хугацааны зөрүү, энэ нь тухайн санхүүгийн тайланд тусгасан тайлант хугацаанаас уг төсвийн тайлант хугацаа өөр байх үед үүсдэг; ба
  - (в) Байгууллагын зөрүү, энэ нь санхүүгийн тайланг бэлтгэж буй тухайн байгууллагын нэг хэсэг болох байгууллагууд эсвэл хөтөлбөрүүдийг төсөвт тусгахгүй байх тохиолдолд үүсдэг.

Мөн санхүүгийн тайлангийн болон төсвийн толилуулгын хувьд хэрэглэсэн хэлбэр загвар ба ангиллын бүтцийн хувьд өөр байж болох юм.

- 1.9.43 Энэ Стандартын 1.9.41-р параграфтаар шаардсан тохируулга нь төсвийн сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн ба мөнгөн орлого, зарлагын тайланд хүлээн зөвшөөрсөн нийт мөнгөн орлого, нийт мөнгөн зарлагын хоорондох зөрүүгийн гол эх үүсвэрүүдийг тогтоосноор өөрийн хариуцлагын үүргийг илүү сайн биелүүлэх боломжийг тухайн байгууллагад олгодог. Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтэнд толилуулсан гол нийт дүн болон дэд дүн нэг бүрийг эсвэл зүйлсийн анги тус бүрийг тухайн санхүүгийн тайлан дахь адилтгах дүнгүүдтэй тохируулахыг энэ Стандартаар хориглодоггүй.
- 1.9.44 Төсвийн баримт бичиг ба санхүүгийн тайлангийн аль алиныг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг мөрддөг байгууллагуудын хувьд, төсвийг санхүүгийн тайлантай нэг ижил хугацаагаар бэлтгэдэг, төсөвт нэг ижил байгууллагуудыг тусган оруулдаг, санхүүгийн тайлантай ижил толилуулгын хэлбэр загварыг ашигладаг бол тохируулга хийх шаардлагагүй байдаг. Төсөв болон санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нэг ижил суурийг мөрддөг өөр бусад байгууллагуудын хувьд толилуулгын хэлбэр загвар, тайлагнагч байгууллага эсвэл тайлант үе нь өөр өөр байж болно. Жишээлбэл; тухайн батлагдсан төсөв нь санхүүгийн тайлангаас өөр ангилал буюу толилуулгын хэлбэр загварыг мөрддөг, уг байгууллагын зөвхөн худалдаа арилжааны бус үйл ажиллагааг тусгадаг эсвэл олон жилийн төсөв байж болно. Нягтлан бодох бүртгэлийн нэг ижил сууриар бэлтгэдэг төсөв ба санхүүгийн тайлангийн хооронд толилуулгын, цаг хугацааны эсвэл байгууллагын зөрүүтэй тохиолдолд ийм тохируулга хийх зайлшгүй шаардлагатай юм.
- 1.9.45 ***Өмнөх тайлант үеийн хувьд энэ Стандартын шаардлагуудын дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулга хийх шаардлагагүй юм.***
- 1.9.46 Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллагуудын санхүүгийн тайланд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг тусгахыг энэ Стандартаар шаарддаг. Энэ Стандарт нь өмнөх тайлант үеийн гүйцэтгэлийг тэрхүү өмнөх тайлант үеийн төсөвтэй зэрэгцүүлсэн тодруулга хийхийг шаарддаггүй, мөн уг өмнөх тайлант үеийн гүйцэтгэл ба төсвийн хоорондох зөрүүгийн талаархи холбогдох тайлбаруудыг тухайн тайлант үеийн санхүүгийн тайланд тодруулахыг шаарддаггүй.

### **Нэгдүгээр хэсгийн 1.9-р дэд хэсгийн хүчин төгөлдөр болох хугацаа**

- 1.9.47 ***Байгууллага нь энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын 1.9-р дэд хэсгийг 2009 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг дэмжинэ. Хэрэв байгууллага нь энэ Стандартын 1.9-р дэд хэсгийг 2009 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.***
- 1.9.48 Байгууллага нь 1.9.47-р параграфт заасан, 1.9-р дэд хэсгийн хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш энэ Стандартыг мөрдсөн бол энэ

Стандартын 1.9.1-1.9.46-р параграфуудыг уг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах тухайн байгууллагын жилийн санхүүгийн тайланд мөрдөнө.

## **1.10 Гадаад тусламж хүлээн авагчид**

### **Тодорхойлолт**

1.10.1 *Дараах нэр томъёог энэ Стандартад доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:*

Хариуцуулсан гадаад тусламж гэдэг нь өөр байгууллагад тухайн хүлээн авагч хариуцуулж, тэрхүү хариуцагч байгууллагын хүлээн авсан аливаа гадаад тусламж бөгөөд үүнд гадаадын буцалтгүй тусламж, техникийн тусламж, баталгаа буюу бусад тусламж хамаарна.

Гадаадын хоёр талт тусламжийн агентлаг гэдэг нь үндэсний гадаад тусламжийн зорилгоор, үүн дотроо үндэсний бүх буюу зарим гадаад тусламжийг үзүүлэх зорилгоор тухайн үндэсний хууль, зохицуулалт болон үндэсний бусад бүрэн эрхийн дагуу үүсгэн байгуулагдсан агентлаг юм.

Гадаад тусламж гэдэг нь хүлээн авагч өөрийн зорилгыг биелүүлэхэд ашиглах буюу өөр бусад байдлаар өгөөж хүртэж болох албан ёсны бүх нөөц юм.

Гадаадын олон талт тусламжийн агентлаг гэдэг нь гадаад тусламжийн зорилгоор, үүн дотроо гадаад тусламж үзүүлэх зорилгоор олон улсын гэрээ буюу хэлэлцээрийн дагуу үүсгэн байгуулагдсан агентлаг юм.

Төрийн бус байгууллага (ТББ) гэдэг нь засгийн газар (газрууд), засгийн газрын агентлагууд, бусад байгууллагууд буюу хувь хүмүүст тусламж үзүүлэх зорилгоор, аливаа засгийн газрын хяналтаас хараат бусаар үүсгэн байгуулсан гадаадын болон үндэсний бүх агентлагууд юм.

Албан ёсны нөөц гэдэг нь тусламж олгож буй эсвэл олгохоор амласан засгийн газар болон засгийн газрын агентлагтай нэг ижил улсын биш, тийм хүлээн авагчид заавал биелүүлэх хэлцлийн дагуу гадаадын олон талт буюу хоёрт талт тусламжийн агентлагуудаас, эсвэл засгийн газар буюу засгийн газрын агентлагаас олгосон эсвэл амласан бүх зээл, буцалтгүй тусламж, техникийн тусламж, баталгаа болон бусад тусламж юм.

Дамжуулан зээлдүүлсэн гадаад тусламжийн зээл гэдэг нь өөр байгууллагад тухайн хүлээн авагч зээлдүүлж, тэрхүү өөр байгууллага зээлдэн авсан гадаад тусламжийн зээл юм.

1.10.2 Янз бүрийн байгууллагууд нь гадаад тусламж буюу гадаад тусламжийн ангиудын хувьд өөр өөр нэр томъёог ашиглаж болох юм. Жишээлбэл;



зарим байгууллагууд нь гадаад тусламжийн оронд гадаадын туслалцаа эсвэл туслалцаа гэсэн нэр томъёог ашиглаж болно. Ийм тохиолдолд өөр өөр нэр томъёо нь будлиан үүсгэх магадлал багатай юм. Гэвч өөр зарим тохиолдолд тухайн нэр томъёо нь эрс ялгаатай байж болох юм. Тийм тохиолдолд нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн бэлтгэгчид, аудиторунд болон хэрэглэгчид нь энэ Стандартын шаардлагуудыг мөрдөх эсэхийг тогтоохдоо зөвхөн уг нэр томъёог биш, харин тодорхойлолтын мөн чанарыг харгалзан үзэх хэрэгтэй.

### **Гадаад тусламж**

- 1.10.3 Хүлээн авагч нь өөрийн зорилгыг биелүүлэхэд ашиглах буюу өөр бусад байдлаар өгөөж хүртэж болох албан ёсны бүх нөөц гэж гадаад тусламжийг 1.10.1-р параграфт тодорхойлсон. Төрийн бус байгууллагууд (ТББ-ууд)-аас олгох тусламжийг заавал биелүүлэх хэлцлийн дагуу олгосон байлаа ч гэсэн 1.10.1-р параграфт тодорхойлсон, албан ёсны нөөцөд хамаарахгүй. Мөнгөн хандив эсвэл гуравдагч тал дахь үүргийн барагдуулалт хэлбэрээр ТББ-уудаас хүлээн авсан тусламжийг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.1-1.9-р дэд хэсгүүдийн шаардлагуудын дагуу санхүүгийн тайланд толилуулж, тайлбар тэмдэглэл хэсэгт тодруулна. 1.10.1-1.10.27-р параграфт заасан тодруулгуудыг ТББ-аас авсан тусламжийн хувьд хэрэв практик боломжтой бол мөрдөхийг 2.1.64-р параграфтаар сайшаан дэмждэг боловч заавал шаарддаггүй.
- 1.10.4 ТББ-ууд нь аливаа засгийн газрын хяналтаас хараат бусаар үүсгэн байгуулагдсан гадаадын буюу үндэсний агентлагууд гэж 1.10.1-р параграфт тодорхойлсон. Зарим цөөн тохиолдолд донор байгууллага нь гадаадын хоёр талт буюу олон талт тусламжийн агентлаг, эсвэл ТББ эсэх, иймээс аливаа засгийн газрын хяналтаас хараат бус эсэх нь тодорхойгүй байж болох юм. Ийм донор байгууллага нь заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүдийн дагуу тусламж үзүүлдэг буюу үзүүлэхээр амалдаг тохиолдолд энэ Стандартад тодорхойлсон албан ёсны нөөц ба ТББ-аас олгосон нөөцийн хоорондох зааг ялгаа бүрхэг байж болно. Ийм тохиолдолд уг хүлээн авсан тусламж нь гадаад тусламжийн тодорхойлолтыг хангах эсэх, ингэснээр энэ хэсэгт тусгайлан заасан тодруулгын шаардлагуудад хамаарах эсэхийг тодорхойлохын тулд мэргэжлийн шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг.

### **Албан ёсны нөөц**

- 1.10.5 Тусламж олгож буй эсвэл олгохоор амласан засгийн газар болон засгийн газрын агентлагтай нэг ижил улсын биш, тийм хүлээн авагчид заавал биелүүлэх хэлцлийн дагуу гадаадын олон талт буюу хоёрт талт тусламжийн агентлагуудаас, эсвэл засгийн газар буюу засгийн газрын агентлагаас олгосон эсвэл амласан нөөц гэж албан ёсны нөөцийг 1.10.1-р параграфт тодорхойлсон. Албан ёсны нөөцийн тодорхойлолтод дурдсан засгийн газар гэдэгт аливаа улсын үндэсний буюу мужийн засгийн газар, бүсийн болон орон нутгийн засаг захиргаа хамаарч болох юм. Иймээс тухайлбал, нэг улсын үндэсний буюу мужийн засгийн газрын агентлагаас

нөгөө улсын мужийн буюу орон нутгийн засаг захиргаанд олгох тусламж нь энэ Стандартад тодорхойлсон, гадаад тусламж болно. Харин нэг улсын үндэсний буюу мужийн засгийн газраас тухайн улсын засгийн газрын бусад түвшинд олгож буй тусламж нь албан ёсны нөөцийн тодорхойлолтыг хангахгүй, иймээс гадаад тусламж биш юм.

### **Гадаад тусламжийн хэлэлцээр**

1.10.6 Тодорхой хэлбэрийн гадаад тусламж авахыг эрмэлзэж буй Засгийн газрууд нь донор байгууллагуудтай албан ёсны уулзалт буюу дугуй ширээний ярилцлага хийж болох юм. Үүнд: тухайн засгийн газрын макро эдийн засгийн төлөвлөгөө ба түүний хөгжлийн тусламжийн хэрэгцээ шаардлагыг авч хэлэлцэх уулзалт, эсвэл худалдааны санхүүжилт, цэргийн тусламж, төлбөрийн тэнцэл болон тусламжийн бусад хэлбэрүүдийн талаархи хоёр талын засгийн газрын түвшний уулзалт ярилцлага хамаарч болно. Мөн ийм хэрэгцээ шаардлага үүссэн тус улсын яаралтай тусламжийн хэрэгцээг авч хэлэлцэх тусдаа уулзалт нь үүнд хамаарна. Эхний хэлэлцүүлгээр санаа зорилгын буюу амлалтын мэдэгдлийг гаргаж болох бөгөөд энэ нь тухайн засгийн газар буюу гадаад тусламжийн агентлагийн хувьд заавал биелүүлэх үүрэг биш байдаг. Гэвч хүлээн авагч байгууллага нь мөнгө санд тавигдах аливаа хязгаарлалтыг биелүүлсэн бөгөөд тохиролцсон нөхцөл буюу болзлыг даган мөрдсөн бол тусламжийн зээл эсвэл буцалтгүй тусламжийг олгох заавал биелүүлэх хэлцлийг дараа нь байгуулж болох юм.

1.10.7 Гадаад тусламжийн хэлэлцээрээр тухайн байгууллагад дараах нөхцлийг олгож болох юм:

- (а) Зээл буюу буцалтгүй тусламжийн нийт мөнгөн орлогыг, эсвэл уг зээл, буцалтгүй тусламжийн тодорхой хэсгийг мөнгөөр хүлээн авах;
- (б) Зээлийн буюу буцалтгүй тусламжийн хэлэлцээрт заасан, тухайн байгууллагын үүргийг мөнгөөр барагдуулснаар гуравдагч талд тэрхүү байгууллагын төлсөн шалгуур хангах төлбөрийг нөхөн авах; эсвэл
- (в) Зээлийн буюу буцалтгүй тусламжийн хэлэлцээрт заасан, тухайн хүлээн авагч байгууллагын үүргийг, үүн дотроо ТББ-аас авсан буюу авах бараа, үйлчилгээний хувьд тэрхүү хүлээн авагч байгууллагын хүлээх үүргийг мөнгөөр барагдуулж, гуравдагч талд төлбөрийг шууд төлөхийг тус гадаад тусламжийн агентлагаас хүсэх.

Тухайн хүлээн авагчид мөнгөн бус хэлбэрээр олгох бараа, үйлчилгээ нь гадаад тусламжийн хэлэлцээрт бас хамаарч болох юм.

### **Хүлээн авсан гадаад тусламж**

1.10.8 ***Байгууллага нь тайлант үеийн туршид мөнгөөр хүлээн авсан нийт гадаад тусламжийг Мөнгөн орлого, зарлагын тайланд тусад нь тодруулна.***

1.10.9 ***Байгууллага нь тайлант үеийн туршид түүний үүргийг шууд барагдуулах эсвэл тухайн байгууллагын өмнөөс бараа, үйлчилгээ***

**худалдан авахын тулд гуравдагч талын төлсөн нийт гадаад тусламжийг Мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт тусад нь тодруулах бөгөөд дараах зүйлсийг тус тусад нь харуулна:**

- (а) **Уг тайлагнагч байгууллагын харъяалагддаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг хэсэг болох гуравдагч талын төлсөн нийт төлбөр; ба**
- (б) **Уг тайлагнагч байгууллагын харъяалагддаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг хэсэг биш гуравдагч талын төлсөн нийт төлбөр.**

**Тайлант үеийн туршид төлбөр хийгдсэн талаар гуравдагч талаас эсвэл төлбөрийг хүлээн авагчаас тухайн байгууллагад албан ёсоор мэдэгдсэн буюу уг төлбөрийг өөр бусад байдлаар шалгасан зөвхөн тийм тохиолдолд эдгээр тодруулгыг хийнэ.**

1.10.10 **Нэгээс олон хандивлагчаас гадаад тусламж хүлээн авдаг тохиолдолд тусламж олгогчдын гол ангиудыг Мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусад нь тодруулна.**

1.10.11 **Гадаад тусламжийг зээл ба буцалтгүй тусламж хэлбэрээр хүлээн авсан тохиолдолд тухайн тайлант үеийн туршид зээл хэлбэрээр авсан нийт дүн болон буцалтгүй тусламж хэлбэрээр авсан нийт дүнг Мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусад нь харуулна.**

1.10.12 Гадаад тусламжийг тухайн тайлагнагч байгууллагад мөнгөн хэлбэрээр шууд олгож болох юм. Өөр нэг хувилбар бол гуравдагч тал нь уг тайлагнагч байгууллагын үүргийг барагдуулах эсвэл тухайн тайлагнагч байгууллагын өмнөөс бараа, үйлчилгээг худалдан авах замаар гадаад тусламжийг үзүүлж болно. Зарим тохиолдолд:

- (а) Гуравдагч тал нь уг тайлагнагч байгууллагын харъяалагддаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг хэсэг байж болно. Жишээлбэл; засгийн газар нь төвлөрсөн төрийн сангийн чиг үүрэг буюу “нэг данс”-ны зохицуулалтаар дамжуулан өөрийн бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын зарлагыг удирддаг тийм улс орны хувьд тухайн хэлтэс газрын хэрэгжүүлэх хөтөлбөрийн өмнөөс мөнгөн хэлбэрийн гадаад тусламжийг олгодог бол ийм тохиолдол үүсдэг. Ийм нөхцөлд, төрийн сан буюу бусад төв агентлаг нь гадаад тусламжийг хүлээн авч, тухайн хэлтэс газраас зохих зөвшөөрөл ба баримтжуулалтыг авсны дараа тэрхүү хэлтэс газрын өмнөөс уг гадаад тусламж байдлаар олгосон дүнгийн төлбөрийг хийдэг; эсвэл
- (б) Гуравдагч тал нь уг тайлагнагч байгууллагын харъяалагддаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг хэсэг биш байж болно. Жишээлбэл; тусламжийн агентлаг нь засгийн газрын агентлагийн өмнөөс түүний өрийг бүсийн хөгжлийн банкинд буцаан төлөх,

тодорхой нэг засгийн газрын агентлагт зам барьж өгөхдөө мөнгө санг түүнд шууд олгохын оронд, барилгын компанид төлбөрийг шууд төлөх, тайлант үеийн туршид үйлчилгээ нийлүүлэгчдэд төлбөрийг шууд төлөх эсвэл шаардлагатай хангамжийн зүйлсийг уг засгийн газрын өмнөөс худалдан авах замаар бие даасан аймгийн буюу хотын захиргааны эрүүл мэндийн болон боловсролын хөтөлбөрийн үйл ажиллагааг санхүүжүүлдэг бол ийм тохиолдол үүсэж болно.

- 1.10.13 Мөнгөн хэлбэрээр болон тухайн байгууллагын өмнөөс гуравдагч талын хийсэн төлбөр хэлбэрээр хүлээн авсан гадаад тусламжийн дүнгийн тодруулга нь уг тайлагнагч байгууллагын үйл ажиллагааг татвар буюу дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлдэг хэмжээг, эсвэл гадаад тусламжаас хамааралтай гэдгийг илтгэн харуулна. Тухайн тайлант үеийн туршид гуравдагч талын төлсөн гадаад тусламжийг уг тайлагнагч байгууллагад албан ёсоор мэдэгдсэн буюу төлбөр төлөлтийг өөр бусад байдлаар шалгасан зөвхөн тийм тохиолдолд ийм төлбөрийг энэ Стандартын 1.3.24-р параграфын шаардлагуудын дагуу, Мөнгөн орлого, зарлагын тайланд тодруулах хэрэгтэй. Мөн хүлээн авсан гадаад тусламжийн гол ангиудын тодруулга хийхийг заавал шаардаагүй боловч сайшаан дэмждэг (2.1.66-р параграфыг үзнэ үү).
- 1.10.14 Тухайлбал; олон улсын донорууд, хоёр талт хамтын ажиллагааны донорууд, олон улсын тусламжийн байгууллагууд, үндэсний тусламжийн байгууллагууд гэх мэт тусламж үзүүлэгчдийн гол ангиуд буюу тайлагнагч байгууллагад тохиромжтой бусад гол ангиудын тодруулга нь тодорхой төрлийн хандивлагчдаас уг байгууллага хараат байх хэмжээг тодорхойлдог бөгөөд тухайн тусламжийн тогтвортой байдлын үнэлгээнд ач холбогдолтой байдаг. Энэ Стандарт нь тусламж үзүүлэгч нэг бүрийн нэр тайлбар буюу тэдгээрийн тус бүрийн үзүүлсэн тусламжийн дүнгийн талаар тодруулга хийхийг шаарддаггүй. Гэвч тус бүрийн үзүүлсэн тусламжийн дүнг тухайн олгосон валютаар нь тодруулахыг сайшаан дэмждэг (2.1.70-р параграфыг үзнэ үү).
- 1.10.15 Гадаад тусламж нь тухайн байгууллагын толилуулгын валютаас ихэвчлэн өөр валютаар илэрхийлэгдсэн байдаг. Гадаад валютаар гарсан ажил гүйлгээний үр дүнд байгууллагын өмнөөс гуравдагч талын хийсэн мөнгөн орлого, зарлагыг энэ Стандартын 1.7.2-р параграфт заасанчлан, уг орлого, зарлага гарсан өдрийн толилуулгын валют болон гадаад валютын хоорондох ханшаар тэрхүү гадаад валютын дүнг үржүүлж, тухайн байгууллагын толилуулгын валютаар бүртгэнэ.
- 1.10.16 Үндэсний засгийн газар нь гадаадын олон талт буюу хоёр талт тусламжийн агентлагуудтай гадаад тусламжийн хэлэлцээр байгуулах онцгой эрхийг ихэвчлэн эзэмшдэг. Ийм олон тохиолдолд төсөл буюу үйл ажиллагааг өөр байгууллага хэрэгжүүлдэг. Үндэсний засгийн газар нь хүлээн авсан мөнгө сангаа өөр байгууллагад дамжуулан зээлдүүлэх буюу хариуцуулж болох юм. Дамжуулан зээлдүүлсэн буюу хариуцуулсан мөнгө сангийн нөхцөл, болзол нь гадаад тусламжийн агентлагаас хүлээн авсан нөхцөлтэй ижил эсвэл өөр байж болно. Зарим тохиолдолд уг үндэсний засгийн газрын

захиргааны зардлыг нөхөхийн тулд бага хэмжээний хураамж буюу хүүний тархалт тооцож болох юм. Гадаад тусламжийн хэлэлцээр байгуулж, түүний үр өгөөж, түүнчлэн уг хэлэлцээрийн нөхцөл, болзлыг өөр байгууллагад дэд хэлэлцээрийн дагуу шилжүүлдэг байгууллага нь тухайн гадаад тусламжийг хүлээн авснаар хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Тус байгууллага нь хоёрдогч байгууллагад олгосон төлбөрийг өөрийн санхүүгийн тайланд мөрддөг төлбөрийн ердийн ангиллын дагуу бас бүртгэнэ.

- 1.10.17 Зээл буюу буцалтгүй тусламжийн анхны хүлээн авагч нь зээл буюу буцалтгүй тусламжийн мөнгөн орлого, нөхцөл, болзлыг өөр байгууллагад шилжүүлдэг тохиолдолд тэрхүү анхны байгууллага нь тухайн зээл, буцалтгүй тусламжийг авахад уг эцсийн хэрэглэгчийн өмнөөс зөвхөн туслалцаа үзүүлдэг байж болох юм. Нөхцөл, болзлууд нь бараг ижил тохиолдолд энэ Стандартын 1.3.13-р параграфт заасанчлан, уг туслалцаа үзүүлэгчийн санхүүгийн тайланд тухайн ажил гүйлгээг цэвэр дүнгээр тусгах нь тохиромжтой байж болно.

### **Зарцуулаагүй гадаад тусламж**

- 1.10.18 *Тухайн хүлээн авагч ашиглах боломжтой зээл буюу буцалтгүй тусламжийн дүнг заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заасан бөгөөд тэрхүү дүнг ашиглах эсэхийг тодорхойлох буюу түүнд нөлөө үзүүлэх аливаа чухал нөхцөл, болзол биелэгдэх өндөр магадлалтай бол, зөвхөн тийм тохиолдолд тус байгууллага нь ирээдүйн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглах боломжтой ба тайлангийн өдрөөр зарцуулаагүй байгаа гадаад тусламжийн зээл болон буцалтгүй тусламжийн үлдэгдлийг санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт тодруулна, ингэхдээ дараах зүйлсийг толилуулгын валютаар тусад нь харуулна:*

(а) *Гадаад тусламжийн зээлийн нийт дүн; ба*

(б) *Гадаад тусламжийн буцалтгүй тусламжийн нийт дүн.*

*Зарцуулаагүй тусламжийг ашиглах эсэхийг тодорхойлох буюу түүнд нөлөө үзүүлэх гол чухал нөхцөл, болзлыг мөн тодруулах хэрэгтэй.*

- 1.10.19 Заавал биелүүлэх хэлцэл (хэлцлүүд)-ийн дагуу амласан боловч хараахан зарцуулаагүй байгаа гадаад тусламжийн дүн нь мэдэгдэхүйц их хэмжээтэй байж болно. Зарим тохиолдолд тусламжийн зээл буюу буцалтгүй тусламжийн дүнг заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заадаг бөгөөд тухайн дүнг ашиглахын тулд хангах шаардлагатай аливаа мэдэгдэхүйц нөхцлүүд биелэх өндөр магадлалтай байдаг. Тухайн нөхцлүүд хангагдсан ба цаашид хангагдсан хэвээр байх одоо хэрэгжиж буй төслүүд, түүнчлэн хэлцлийн нөхцлийн дагуу үргэлжлэхээр урьдчилан таамагласан төслийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийн хувьд ийм тохиолдол үүсэж болно. Ийм зарцуулаагүй үлдэгдлийг гадаад валютаар олгодог тохиолдолд энэ Стандартын 1.7.3-р параграфт заасны дагуу тухайн тайлангийн

өдрөөрх валютын ханшаар уг гадаад валютыг үржүүлснээр эхний болон эцсийн үлдэгдлийг тодорхойлно.

1.10.20 Зарим тохиолдолд донор байгууллага нь тухайн тайлагнагч байгууллагад үргэлжлүүлэн тусламж үзүүлэх санаа зорилготой байгаагаар илэрхийлсэн боловч ирээдүйн тайлант үеүдэд олгох уг тусламжийн зээл (зээлүүд) буюу буцалтгүй тусламжийн (тусламжуудын) дүнг заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заагаагүй байж болох юм. Жишээлбэл; олгох тусламжийн дүн нь уг донор улсын жилийн төсвөөс, эсвэл тэрхүү хүлээн авагчийн олж авч болох санхүүжилтийн бусад эх үүсвэрээс хамааралтай бол ийм тохиолдол үүсэж болно. Өөр зарим тохиолдолд тусламжийн дүнг тусгайлан заасан боловч биелэх өндөр магадлалтай гэж тухайн тайлангийн өдрөөр үнэлж чадахааргүй тийм нөхцөл, болзолтой байж болно. Жишээлбэл; тусгайлан заасан гүйцэтгэлийн шалгуур хангагдсанаар олгогдох төлбөрийн тэнцлийн тусламж эсвэл бусад агентлагуудын олгох тусламжийн дүнгээс хамааран олгох яаралтай тусламжийн хувьд ийм тохиолдол үүсэж болох юм. Ийм тохиолдолд уг зарцуулаагүй дүнгийн талаар тодруулга хийхгүй. Зарим тохиолдолд гадаад тусламжийг ашиглаж болох эсэхийг тодорхойлох буюу түүнд нөлөө үзүүлэх чухал нөхцөл, болзлын биелэлт өндөр магадлалтай эсэхийг үнэлэхдээ мэргэжлийн шүүн тунгаалт хийх шаардлагатай байж болно.

#### **Бараа, үйлчилгээний хүлээн авалт**

1.10.21 ***Байгууллага нь бараа, үйлчилгээ хэлбэрээр хүлээн авсан гадаад тусламжийн үнэ цэнийг тодруулах сонголт хийсэн тохиолдолд уг үнэ цэнийг тодорхойлсон суурийг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд бас тодруулна.***

1.10.22 Байгууллага нь бараа, үйлчилгээ хэлбэрээр хүлээн авсан гадаад тусламжийн үнэ цэнийг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусад нь тодруулахыг энэ Стандартын 2.1.90-р параграфтаар сайшаан дэмжсэн байдаг. Уг сайшаан дэмжсэн тодруулгыг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусгасан тохиолдолд тэдгээр нь ойлгомжтой бөгөөд санхүүгийн мэдээллийн бусад чанарын шинжүүдийг хангасан байх шаардлагатай гэдгийг энэ Стандартын 1.3.38-р параграфт тайлбарласан. Байгууллага нь ийм тодруулга оруулах сонголт хийсэн тохиолдолд тэрхүү үнэ цэнийг тодорхойлсон суурийг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулах шаардлагатай юм. Ийм тодруулга нь үнэ цэнийг тухайлбал, донорын үнэлгээг харгалзсанаар тодорхойлсон, эсвэл олон улсын болон дотоодын зах зээлийн үнийг лавлагаа болгосноор, эсвэл удирдлагын үнэлэмж буюу бусад сууриар бодит үнэ цэнийг тодорхойлсон эсэхийг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог.

#### **Дахин хуваарь хийсэн эсвэл хүчингүй болгосон өрийн тодруулга**

1.10.23 ***Байгууллага нь тайлант үеийн туршид дахин хуваарь хийсэн эсвэл хүчингүй болгосон гадаад тусламжийн дүнг холбогдох аливаа***

***нөхцөл, болзлын хамтаар санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулна.***

1.10.24 Гадаад тусламжийн өрөө барагдуулахад хүндрэл учраад буй байгууллага нь уг өрийн нөхцөл, болзлыг дахин хэлэлцэх эсвэл өрийг хүчингүй болгохыг эрмэлзэж болох юм. Дахин хуваарь хийсэн эсвэл хүчингүй болгосон гадаад тусламжийн өрийн дүнг холбогдох аливаа нөхцөл, болзлын хамтаар тодруулах нь ийм дахин хэлцэл буюу хүчингүй болголт хийгдсэн талаар тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд анхааруулга дохио өгдөг. Энэ нь уг байгууллагын санхүүгийн байдал болон түүний өөрчлөлтийн үнэлгээний хувьд ач холбогдолтой орц өгөгдлөөр хангадаг.

**Чухал нөхцөл ба болзлын үл биелүүлэлтийн талаархи тодруулга**

1.10.25 ***Гадаад тусламжийн зээл буюу буцалтгүй тусламжийн хэлэлцээр, эсвэл баталгааны гол чухал нөхцөл, болзлыг үл биелүүлэх нь уг тусламжийг хүчингүй болгох буюу өмнө олгосон тусламжийг буцаах үүрэг хүлээлгэх тийм үр дагавартай тохиолдолд байгууллага нь тайлант үеийн туршид даган мөрдөөгүй тэдгээр нөхцөл, болзлыг санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт тодруулна. Хүчингүй болгосон буюу буцаан өгөх гадаад тусламжийн дүнг бас тодруулна.***

1.10.26 Гадаад тусламжийн хэлэлцээр нь уг тусламжийн мөнгө санг үргэлжлүүлэн авахын тулд даган мөрдөх ёстой нөхцөл, болзол түүнчлэн горимын шинжтэй зарим нөхцөл, болзлыг ихэвчлэн тусгасан байдаг.

1.10.27 1.10.25-р параграфтаар шаардсан тодруулга нь тухайн байгууллагын ирээдүйн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бэлэн боломжтой мөнгө санд сөргөөр нөлөөлсөн ийм үл биелүүлэлтийн тохиолдлыг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгоно. Энэ нь уг хэлэлцээрийн даган мөрдөлтийг ирээдүйд дахин тогтоож болох эсэх үнэлгээний хувьд орц өгөгдлөөр бас хангадаг. Өөр бусад тохиолдолд гол чухал нөхцөл, болзлын үл биелүүлэлтийн талаар тодруулга хийхийг мөн сайшаан дэмждэг боловч заавал шаарддаггүй (2.1.83-р параграфыг үзнэ үү).

**1.10-р дэд хэсгийн хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилтийн нөхцлүүд**

1.10.28 ***Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын 1.10.1-1.10.34-р параграфууд нь 2009 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд хүчин төгөлдөр үйлчилнэ.***

1.10.29 ***Энэ Стандартын 1.10.1-1.10.34-р параграфуудыг мөрдсөн эхний жилд, байгууллагууд нь 1.10.1-1.10.27-р параграфуудын дагуу тодруулсан дүнгүүдийн хувьд зэрэгцүүлэгдэх дүнг тодруулах шаардлагагүй юм.***

- 1.10.30 **Энэ Стандартын 1.10.1-1.10.34-р параграфуудыг анх мөрдсөн өдрөөс хойш хоёр жилийн тайлант хугацаанд байгууллагууд нь 1.10.18-р параграфт тусгайлан заасанчлан, зарцуулаагүй гадаад тусламжийн үлдэгдлийг санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт тусад нь тодруулах шаардлагагүй юм.**
- 1.10.31 **Байгууллага нь 1.10.29 ба 1.10.30-р параграфт заасан шилжилтийн нөхцлийг мөрдөж байгаа тохиолдолд ингэж мөрдөж буй талаар тодруулга хийнэ.**
- 1.10.32 Энэ Стандартын 1.10.1-1.10.27-р параграфын шаардлагуудыг мөрдсөн эхний жилийн хувьд, зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулга хийх уг шаардлагыг биелүүлэх боломжийг түүнд олгох хэрэгцээт мэдээлэлд тухайн байгууллага нь шууд буюу ул үндэслэлтэйгээр хандан нэвтрэх боломжгүй байж болно. Мөн 1.10.18-р параграфтаар шаардсанчлан, байгууллага нь зарцуулаагүй гадаад тусламжийн эцсийн үлдэгдлийг тодруулахад түүнд шаардлагатай мэдээлэлгүй байж болох юм.
- 1.10.33 Тус Стандартыг анх мөрдөхөөс өмнөх тайлант үеийн хувьд зэрэгцүүлэгдэх мэдээллийг тодруулах шаардлагаас чөлөөлөхөөр энэ Стандартын 1.4.16-р параграфт заасан. 1.10.1-1.10.27-р параграфт тусгайлан заасанчлан, гадаад тусламж хүлээн авагчдын хийх мэдээллийн тодруулгатай холбоотой шаардлагуудыг энэхүү Мөнгөн суурьт УСНББОУС-т оруулахын тулд түүнд нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө, зарим байгууллагууд нь түүнийг мөрддөг байсан байж болох юм. Энэ Стандартын 1.10.1-1.10.27-р параграфт тусгайлан заасанчлан, эдгээр параграфуудыг мөрдсөн эхний жилд гадаад тусламжийн талаархи зэрэгцүүлэгдэх мэдээллийг тодруулах тэрхүү шаардлагаас чөлөөлөхөөр 1.10.29-р параграфт заасан. 1.10.18-р параграфыг анх мөрдсөнөөс хойшхи хоёр жилийн хугацаанд уг параграфын шаардлагаас чөлөөлөхөөр 1.10.30-р параграфт заасан.
- 1.10.34 Энэ Стандартын шаардлагуудыг хэрхэн даган мөрдсөн талаар хэрэглэгчдэд мэдээлэхийн боломжийг бүрдүүлэхийн тулд эдгээр шилжилтийн нөхцлүүдийг ашиглаж буй байгууллага нь энэ тухай тодруулга хийхийг 1.10.31-р параграфтаар шаардсан.



## Хавсралт 1

### Энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн шаардлагуудын үлгэрчилсэн жишээ

Энэхүү Хавсралт нь зөвхөн үлгэрчилсэн жишээ бөгөөд тус Стандартын нэг хэсэг болохгүй. Тухайн тайлант үед болон өмнөх тайлант үеүдэд гадаад тусламжийн зээл ба буцалтгүй тусламж хүлээн авсан засгийн газарт хамаарах Мөнгөн орлого, зарлагын тайлан болон холбогдох тэмдэглэл тодруулгын хэсгийг энд үлгэрчлэн харуулсан. Хавсралтын зорилго нь дараах байгууллагуудын хувьд нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу нийтлэг зорилготой санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахад үүнийг хэрхэн мөрдөхийг үлгэрчлэн харуулснаар стандартуудын утгыг тодорхой болгоход туслах явдал юм:

- (а) Гадаад тусламжийг хүлээн авагч болох **Засгийн газар**;
- (б) Банкин дахь өөрийн дансаа хянадаг бөгөөд гадаад тусламж хүлээн авагч бус **Засгийн газрын байгууллага**; ба
- (в) Тухайн хэлтэс газрын өмнөөс мөнгөн орлого, зарлагыг нь төв байгууллага удирддаг тийм “нэг данс”-ны системийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд гадаад тусламж хүлээн авагч бус **Засгийн газрын хэлтэс газар**.

## ХАВСРАЛТ 1А

### “А” ЗАСГИЙН ГАЗРЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

#### 200X ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ОРЛОГО, ЗАРЛАГЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН (Зөвхөн орлого хэсэг)

(мянган валютын нэгжээр)	Тод-руулга	2000X		200X-1	
		Байгууллагын хянаж буй мөнгөн орлого/ (зарлага)	Гуравдагч талын төлбөр	Байгууллагын хянаж буй мөнгөн орлого/ (зарлага)	Гуравдагч талын төлбөр
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>					
<b>Татвар</b>					
Орлогын албан татвар		X	-	X	-
Нэмэгдсэн өртгийн албан татвар		X	-	X	-
Үл хөдлөх хөрөнгийн татвар		X	-	X	-
Бусад татвар		X	-	X	-
			X		X
			-		-
<b>Гадаад тусламж</b>	10				
Олон талт хамтын ажиллагааны агентлагууд		X	X	X	X
Хоёр талт хамтын ажиллагааны агентлагууд		X	X	X	X
			X		X
			X		X

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРЬТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

(мянган валютын нэгжээр)	Тод-руулга	2000X		200X-1	
		Байгууллагын хянаж буй мөнгөн орлого/ (зарлага)	Гуравдагч талын төлбөр	Байгууллагын хянаж буй мөнгөн орлого/ (зарлага)	Гуравдагч талын төлбөр
<b>Бусад буцалтгүй тусламж ба туслалцаа</b>		X	X	X	X
<b>Бусад зээл</b>					
Зээлийн мөнгөн орлого	3	X	X		
<b>Капитал мөнгөн орлого</b>					
Үндсэн хөрөнгийн данснаас хасалтын мөнгөн орлого		X	-	X	-
<b>Худалдаа арилжааны үйл ажиллагаа</b>					
Худалдаа арилжааны үйл ажиллагааны мөнгөн орлого		X	-	X	-
<b>Бусад мөнгөн орлого</b>	4	X	X	X	X
<b>Нийт мөнгөн орлого</b>		<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

(мянган валютын нэгжээр)	Тодруулга	← 200X →		← 200X-1 →	
		Байгууллагын хянаж буй мөнгөн орлого/ (зарлага)	Гуравдагч талын төлбөр	Байгууллагын хянаж буй мөнгөн орлого/ (зарлага)	Гуравдагч талын төлбөр
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>					
<i>Үйл ажиллагаа</i>					
Цалин, хөлс ба ажиллагчдын тэтгэмж Хангамжийн болон хэрэглээний зүйлс					
		(X)	(X)	(X)	(X)
		<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>	<u>(X)</u>
		(X)	(X)	(X)	(X)
<i>Шилжүүлэг</i>					
Буцалтгүй тусламж Бусад шилжүүлгийн төлбөр					
		(X)	-	(X)	-
		<u>(X)</u>	<u>-</u>	<u>(X)</u>	<u>-</u>
		(X)	-	(X)	-
<i>Капитал зарлага</i>					
Үндсэн хөрөнгийн худалдан авалт/барьж байгуулалт Санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалт					
		(X)	(X)	(X)	(X)
		<u>(X)</u>	<u>-</u>	<u>(X)</u>	<u>-</u>
		(X)	(X)	(X)	(X)

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

	Тод- руулга	← 200X →		← 200X-1 →	
		Байгуул- лагын хянаж буй мөнгөн орлого/ (зарлага)	Гурав- дагч талын төлбөр	Байгуул- лагын хянаж буй мөнгөн орлого/ (зарлага)	Гурав- дагч талын төлбөр
(мянган валютын нэгжээр)					
<b>Зээл ба хүүний буцаан төлөлт</b>					
Зээлийн буцаан төлөлт		(X)	-	(X)	-
Хүүний буцаан төлөлт		(X)	-	(X)	-
<b>Бусад төлбөр</b>	5	(X)	(X)	(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлага</b>		(X)	(X)	(X)	(X)
Мөнгөний өсөлт/(бууралт)		X	-	X	-
<b>Мөнгөний жилийн эхний үлдэгдэл</b>	2	X	X/Г	X	X/Г
Мөнгөний өсөлт/(бууралт)		X	X/Г	X	X/Г
<b>Мөнгөний жилийн эцсийн үлдэгдэл</b>	2	X	X/Г	X	X/Г

\* X/Г = Хамааралгүй

**ТӨСӨВ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮНГҮҮДИЙН ЗЭРЭГЦҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**“Х” Засгийн газрын 200X оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жил**

**Мөнгөн сууриар баталсан төсөв  
(Чиг үүргээр хийсэн зарлагын ангилал)**

(мянган валютын нэгжээр)	Гүйцэтгэлийн дүн*	Тодотгосон төсөв	Анхны төсөв	Тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зөрүү**
<b>МӨНГӨН ОРЛОГЫН ГҮЙЛГЭЭ</b>				
Татвар	X	X	X	X
Туслалцааны хэлцэл				
Олон улсын агентлагууд	X	X	X	X
Бусад буцалтгүй тусламж ба туслалцаа	X	X	X	X
Зээлийн орлого	X	X	X	X
Үндсэн хөрөнгө данснаас хасалтын орлого	X	X	X	X
Худалдааны үйл ажиллагаа	X	X	X	X
Бусад мөнгөн орлого	X	X	X	X
<b>Нийт мөнгөн орлогын дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>МӨНГӨН ЗАРЛАГЫН ГҮЙЛГЭЭ</b>				
Эрүүл мэнд	(X)	(X)	(X)	(X)
Боловсрол	(X)	(X)	(X)	(X)
Нийтийн хэв журам/аюулгүй байдал	(X)	(X)	(X)	(X)
Нийгмийн хамгаалал	(X)	(X)	(X)	(X)
Батлан хамгаалах	(X)	(X)	(X)	(X)
Орон сууц, нийтийн аж ахуй	(X)	(X)	(X)	(X)
Амралт зугаалга, соёл, шашин	(X)	(X)	(X)	(X)
Эдийн засаг	(X)	(X)	(X)	(X)
Бусад	(X)	(X)	(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлагын дүн</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
<b>ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

\* Гүйцэтгэлийн дүн нь мөнгөн зарлага болон гуравдагч талаас хийсэн төлбөрийн аль алиныг агуулсан байдаг.

\*\* “...Зөрүү” гэсэн багана заавал байх албагүй юм. Гэвч гүйцэтгэл ба анхны төсвийн, эсвэл тодотгосон төсвийн аль тохиромжтойг тодорхой заасан зэрэгцүүлэлтийг тусган оруулж болох юм.

**НЭМЭЛТ САНХҮҮГИЙН ТАЙЛАН (СОНГОЛТООР)**

Нэгтгэсэн мөнгөн орлого, зарлагын тайланд тусгасан дүнгүүдийн талаархи дэлгэрэнгүй мэдээллээр хангах тухайлбал, сангийн гол бүлгүүдээр мэдээллийг тодруулах, эсвэл зарлагыг гол чиг үүрэг буюу хөтөлбөрөөр тодруулах, эсвэл зээлийн эх үүсвэрийн дэлгэрэнгүй мэдээллээр хангахын тулд нэмэлт санхүүгийн тайланг бэлтгэж болно. Мөн төсөвлөсөн дүнгүүдийг харуулах баганыг тусган оруулж болох юм.

**САНГИЙН АНГИЛЛААР ХАРУУЛСАН МӨНГӨН ОРЛОГЫН ТАЙЛАН**

(мянган валютын нэгжээр)	200X Байгууллагын хянаж буй мөнгөн орлого	200X-1 Байгууллагын хянаж буй мөнгөн орлого
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>		
Нэгтгэсэн сангууд	X	X
Тусгай сангууд	X	X
Худалдааны сангууд	X	X
Зээл	X	X
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>X</b>	<b>X</b>

**ЗЭЭЛИЙН ОРЛОГО**

(мянган валютын нэгжээр)	Тод-руулга	200X		200X-1	
		Байгууллагын хянаж буй мөнгөн орлого	Гуравдагч талын төлбөрөөс үүссэн	Байгууллагын хянаж буй мөнгөн орлого	Гуравдагч талын төлбөрөөс үүссэн
<b>ЗЭЭЛ</b>					
Дотоодын арилжааны санхүүгийн байгууллага		X	-	X	-
Гадаадын арилжааны санхүүгийн байгууллага		X	-	X	-
Хөгжлийн банкууд ба адилтгах зээлдүүлэгч агентлагууд		X	X	X	X
<b>Нийт зээлийн дүн</b>	3	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨТӨЛБӨР/ҮЙЛ АЖИЛЛАГАА/ЧИГ ҮҮРГЭЭР  
ХАРУУЛСАН МӨНГӨН ЗАРЛАГЫН ТАЙЛАН**

(мянган валютын нэгжээр)	← 200X →		← 200X-1 →	
	Байгууллагын хянаж буй мөнгөн зарлага	Гуравдагч талын хийсэн төлбөр	Байгууллагын хянаж буй мөнгөн зарлага	Гуравдагч талын хийсэн төлбөр
<b>ТӨЛБӨР/ЗАРЛАГА</b>				
<b>Үйл ажиллагааны данс</b>				
Боловсролын үйлчилгээ	X	X	X	X
Эрүүл мэндийн үйлчилгээ	X	X	X	X
Нийгмийн хамгаалал ба халамж	X	-	X	-
Батлан хамгаалах	X	-	X	-
Нийгмийн хэв журам, аюулгүй байдал	X	X	X	X
Амралт зугаалга, соёл, шашин	X	X	X	X
Эдийн засаг	X	-	X	-
Бусад	X	X	X	X
<b>Нийт төлбөр/зарлага</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>ТӨЛБӨР/ЗАРЛАГА</b>				
<b>Капитал данс</b>				
Боловсролын үйлчилгээ	X	X	X	X
Эрүүл мэндийн үйлчилгээ	X	X	X	X
Нийгмийн хамгаалал ба халамж	X	-	X	-
Батлан хамгаалах	X	-	X	-
Нийгмийн хэв журам, аюулгүй байдал	X	X	X	X
Амралт зугаалга, соёл, шашин	X	X	X	X
Бусад	X	X	X	X
<b>Нийт төлбөр/зарлага</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Үйл ажиллагааны болон капитал дансдын нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>



## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГА—НИЙТ ЗАСГИЙН ГАЗРЫН ТҮВШИН

### Санхүүгийн тайлангийн тэмдэглэл

#### 1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого

##### Бэлтгэсэн суурь

Санхүүгийн тайланг Мөнгөн суурьт УСНББОУС, “*Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал*”-ын дагуу бэлтгэсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тухайн тайлант үеийн туршид тууштай мөрдсөн.

##### Тайлагнагч байгууллага

Санхүүгийн тайланг “А” улсын үндэсний засгийн газрын хувьд бэлтгэсэн. Тус санхүүгийн тайлан нь холбогдох хууль тогтоомж (Төрийн санхүүгийн хууль 20XX)-д тусгайлан заасанчлан, дараах байгууллагуудаас бүрдэх уг тайлагнагч байгууллагад хамаарна:

- (i) Төв засгийн газрын яамдууд; ба
- (ii) Тус байгууллагын хяналтанд буй Улсын үйлдвэрийн газрууд ба худалдаа арилжааны сангууд.

Тухайн тайлант үеийн туршид хяналтанд байсан бүх байгууллагуудыг уг нэгтгэсэн санхүүгийн тайланд хамруулдаг. Хяналтад буй томоохон байгууллагуудын жагсаалтыг энэхүү санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 7-д харуулсан.

##### Гуравдагч талаас хийсэн төлбөр

Зээл болон хувь оролцооны хэлбэрээр тухайн тайлант үеийн туршид гуравдагч талаас хийсэн мөнгөн төлбөрийн үр дүнд түүний өмнөөс худалдан авсан бараа, үйлчилгээнээс тус засгийн газар нь мөн өгөөж хүртдэг. Гуравдагч талуудаас хийсэн төлбөр нь засгийн газрын мөнгөн орлого, зарлагыг бүрдүүлэхгүй боловч уг засгийн газарт өгөөж бий болгодог. Нэгтгэсэн мөнгөн орлого, зарлагын тайлан дахь *Гуравдагч талын хийсэн төлбөр* баганад болон бусад санхүүгийн тайланд тэдгээрийг тусгасан.

##### Толилуулгын валют

Толилуулгын валют нь (А улсын мөнгөн тэмдэгт) юм.

#### 2. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө нь бэлэн мөнгө, харилцах данс, мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бүрддэг. Харилцах данс ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь банкин дахь дансдын үлдэгдэл болон мөнгөний зах зээлийн богино хугацаат хэрэглүүрт хийсэн хөрөнгө оруулалтаас бүрдэнэ.

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Мөнгөн орлого, зарлагын тайланд тусгасан мөнгөн хөрөнгө нь дараах дүнгүүдээс бүрдэж байна:

(мянган валютын нэгжээр)	<b>200X</b>	<b>200X-1</b>
Бэлэн мөнгө болон банкин дахь дансдын үлдэгдэл	X	X
Богино хугацаат хөрөнгө оруулалт	X	X
	<u>X</u>	<u>X</u>

Дээрх дүнд тусгасан X валютыг “XX” Олон улсын агентлагаас олгосон бөгөөд авто замын дэд бүтцийн барилгын ажилд ашиглах зориулалтаар хязгаарлагдсан болно.

### 3. Зээл

Зээл нь банк, адилтгах зээлдүүлэгч агентлагууд, арилжааны санхүүгийн байгууллагуудаас авсан мөнгөн орлогын гүйлгээ болон гуравдагч талуудаас үзүүлсэн мөнгөн бус тусламжийн хувьд буцаан төлөх дүнгээс бүрддэг.

### 4. Бусад мөнгөн орлого

Бусад мөнгөн орлогод хураамж, торгууль, алданги болон бусад төрөл бүрийн орлогыг тусгасан.

### 5. Бусад төлбөр/зарлага

Бусад төлбөрт ногдол ашиг, олгосон хуваарилалтууд, шүүхийн зарга маргааны барагдуулалтын төлбөр болон бусад төрөл бүрийн төлбөрийг тусгасан.

### 6. Зарцуулаагүй гадаад тусламжаас бусад, зарцуулаагүй зээлийн хэрэгсэл

*(Зарцуулаагүй гадаад тусламжийн хувьд Тэмдэглэл 10-ыг үзнэ үү)*

(мянган валютын нэгжээр)	<b>200X</b>	<b>200X-1</b>
<b>Зарцуулаагүй зээлийн хэрэгслийн хөдөлгөөн</b>		
0X оны 01 дүгээр сарын 01 дэх зарцуулаагүй зээлийн хэрэгсэл	X	X
Нэмэлт зээлийн хэрэгсэл	X	X
Боломжит нийт дүн	<u>X</u>	<u>X</u>
Зарцуулсан дүн	(X)	(X)
Хаагдсан/хүчингүй болгосон хэрэгсэл	<u>(X)</u>	<u>(X)</u>
0X оны 12 дугаар сарын 31 дэх зарцуулаагүй зээлийн хэрэгсэл	X	X

(мянган валютын нэгжээр)	<b>200X</b>	<b>200X-1</b>
<b>Зарцуулаагүй зээлийн хэрэгсэл</b>		
Арилжааны санхүүгийн байгууллага	X	X
Зарцуулаагүй зээлийн хэрэгслийн нийт дүн	<u>X</u>	<u>X</u>

**7. Хяналтад буй томоохон байгууллагууд**

Байгууллага	Улс
“А” Байгууллага	Х
“Б” Байгууллага	Х
“В” Байгууллага	Х
“Г” Байгууллага	Х

**8. Зөвшөөрсөн өдөр**

“А” улсын Төрийн сангийн дарга Ноён ҮҮ нь уг санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг 200Х+1 оны ...-р сарын ХХ өдөр зөвшөөрсөн.

**9. Батлагдсан анхны ба тодотгосон төсөв, гүйцэтгэлийн болон төсвийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт**

Уг батлагдсан төсвийг тухайн санхүүгийн тайланд мөрдсөнтэй ижил нягтлан бодох бүртгэлийн сууриар (мөнгөн суурь), ижил ангиллын сууриар, мөн ижил тайлант хугацааны (200Х оны 1-р сарын 1-нээс 200Х оны 12-р сарын 31-ний) хувьд бэлтгэсэн. Энэ нь нэгтгэсэн санхүүгийн тайланд хамруулсантай ижил байгууллагуудыг агулдаг бөгөөд тэдгээр байгууллагуудыг дээрх Тэмдэглэл 7-д дурдсан.

Анхны төсвийг (огноо)-ны хууль тогтоох ажиллагаагаар баталсан бөгөөд Хойд бүс нутагт (огноо)-нд болсон газар хөдлөлтийн улмаас (огноо)-ны хууль тогтоох ажиллагаагаар гамшгийг арилгахад зориулж ХХХ-ийн нэмэлт төсвийн хуваарилалтыг баталсан. Анхны төсвийн зорилтууд ба бодлого, түүнчлэн дараагийн хянан засварлалтыг тухайн санхүүгийн тайлангийн хамт гаргасан Үйл ажиллагааны тойм болон Төсвийн үр дүнгийн тайланд илүү дэлгэрэнгүй тайлбарласан.

Газар хөдлөлтийн хариу болгон хууль тогтоох ажиллагаагаар баталсан түвшнээс зарлага нь давсаны улмаас Эрүүл мэндийн чиг үүргийн хувьд гүйцэтгэлийн зарлага нь тодотгосон төсвөөс 15 хувиар (анхны төсвөөс 25 хувиар) хэтэрсэн. Өөр материаллаг зөрүү байгаагүй.

**Тодруулга 9-ийн хүвилбар – Төсөв ба санхүүгийн тайланг өөр өөр сууриар бэлтгэдэг тохиолдолд**

**9. Батлагдсан анхны ба тодотгосон төсөв, гүйцэтгэлийн болон төсвийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт**

Төсвийг чиг үүргээр ангилж, тохируулсан мөнгөн сууриар баталдаг. Батлагдсан төсөв нь 200Х оны 01-р сарын 01-нээс 200Х оны 12-р сарын 31-ний төсвийн хугацааг хамрах бөгөөд засгийн газрын үндсэн секторын хүрээн дэх бүх байгууллагуудыг агуулсан байдаг. Засгийн газрын үндсэн секторт засгийн газрын бүх байгууллагууд хамаарах бөгөөд тэдгээр байгууллагуудыг дээрх Тэмдэглэл 7-д дурдсан.

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Анхны төсвийг (огноо)-ны хууль тогтоох ажиллагаагаар баталсан бөгөөд Хойд бүс нутагт (огноо)-нд болсон газар хөдлөлтийн улмаас (огноо)-ны хууль тогтоох ажиллагаагаар гамшгийг арилгахад зориулж ХХХ-ийн нэмэлт төсвийн хуваарилалтыг баталсан. Анхны төсвийн зорилтууд ба бодлого, түүнчлэн дараагийн хянан засварлалтыг тухайн санхүүгийн тайлангийн хамт гаргасан Үйл ажиллагааны тойм болон Төсвийн үр дүнгийн тайланд илүү дэлгэрэнгүй тайлбарласан.

Газар хөдлөлтийн хариу болгон хууль тогтоох ажиллагаагаар баталсан түвшнээс зарлага нь давсаны улмаас Эрүүл мэндийн чиг үүргийн хувьд гүйцэтгэлийн зарлага нь тодотгосон төсвөөс 15 хувиар (анхны төсвөөс 25 хувиар) хэтэрсэн. Батлагдсан тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн хооронд өөр материаллаг зөрүү байгаагүй.

Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн сууриуд өөр байдаг. Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь зардлын шинж төрөлд үндэслэсэн ангиллыг ашиглан нийт засгийн газрын санхүүгийн тайланг мөнгөн сууриар бэлтгэдэг. Тус санхүүгийн тайлан нь 20XX оны 01-р сарын 01-нээс 20XX оны 12-р сарын 31-ний төсвийн хугацааны хувьд хяналтанд буй бүх байгууллагуудыг, үүн дотроо улсын үйлдвэрийн газруудыг хамруулсан, нэгтгэсэн санхүүгийн тайлан юм. Харин төсвийг чиг үүргээр ангилж, тохируулсан мөнгөн сууриар бэлтгэдэг ба засгийн газрын үндсэн секторыг зөвхөн хамрах бөгөөд үүнд улсын үйлдвэрийн газрууд, засгийн газрын зах зээлийн бус бусад зарим байгууллагууд болон үйл ажиллагааг тусгадаггүй.

Тохируулсан мөнгөн суурьтай нийцүүлэхийн тулд уг мөнгөн орлого, зарлагын тайлан дахь дүнгүүдийг тохируулсан бөгөөд батлагдсан, тодотгосон төсөвтэй ижил суурьтай болгох үүднээс чиг үүргийн ангиллаар дахин ангилсан болно. Түүнчлэн, гүйцэтгэлийн дүнгүүдийг тэрхүү батлагдсан, тодотгосон төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлэхийн тулд одоо үргэлжилж буй төсвийн хуваарилалттай холбоотой цаг хугацааны зөрүү болон хамрагдах байгууллагуудын (Улсын үйлдвэрийн газрууд ба бусад байгууллагуудын) зөрүүтэй байдлын хувьд уг мөнгөн орлого, зарлагын тайлан дахь дүнгүүдэд тохируулга хийсэн.

20XX оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайланд толилуулсан гүйцэтгэлийн орлого, гүйцэтгэлийн зарлага болон мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнасан нийт мөнгөн орлого, нийт мөнгөн зарлагын хоорондох тохируулгыг доор харуулав.

	<b>Нийт орлого</b>	<b>Нийт зарлага</b>
Төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлэлтийн тайланд толилуулсан зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн	<b>X</b>	<b>X</b>
Суурийн зөрүү	X	X
Цаг хугацааны зөрүү	-	-
Байгууллагын зөрүү	X	X
Нийт мөнгөн орлого	<b>X</b>	
Нийт мөнгөн зарлага		<b>X</b>

Санхүүгийн тайлан болон төсвийн баримт бичгийг нэг ижил тайлант хугацааны хувьд бэлтгэсэн. Гэвч байгууллагын зөрүүтэй байна: төсвийг засгийн газрын үндсэн секторын хувьд бэлтгэдэг, харин санхүүгийн тайлан нь тухайн засгийн газрын хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэдэг. Мөн суурийн зөрүүтэй байдаг: төсвийг мөнгөн сууриар, санхүүгийн тайланг тохируулсан мөнгөн сууриар бэлтгэдэг.

Энэхүү тохируулгыг Төсөв ба Гүйцэтгэлийн Дүнгүүдийн Зэрэгцүүлэлтийн Тайланд эсвэл тэмдэглэл тодруулгад тусгаж болно.

## 10. Гадаад тусламж

### Гуравдагч талаас хийсэн төлбөр

Гуравдагч талаас хийсэн бүх төлбөр нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг хэсэг биш тийм гуравдагч талуудаас хийсэн төлбөрүүд байна.

### Гадаад тусламж

Гадаад тусламжийг ашиглан зарцуулах зорилгыг тусгайлан заасан хэлэлцээрийн дагуу олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны донор агентлагуудаас зээл ба буцалтгүй тусламж хэлбэрээр гадаад тусламжийг хүлээн авсан. Доорх дүнгүүдийг тухайн байгууллагын толилуулгын валютаар толилуулсан болно.

	<u>200X</u> Нийт дүн	<u>200X-1</u> Нийт дүн
<b>Зээлийн сангууд</b>		
Олон талт хамтын ажиллагааны агентлагууд	X	X
Хоёр талт хамтын ажиллагааны агентлагууд	X	X
Дүн	X	X
<b>Буцалтгүй тусламжийн сангууд</b>		
Олон талт хамтын ажиллагааны агентлагууд	X	X
Хоёр талт хамтын ажиллагааны агентлагууд	X	X
Дүн	X	X
<b>Гадаад тусламжийн нийт дүн</b>	X	X

### Гол чухал нөхцөл, болзлын үл биелүүлэлт, дахин хуваарь хийсэн болон хүчингүй болгосон өр

Гадаад тусламжийн зээлийг цуцлахад хүргэх тийм гол чухал нөхцөл, болзлыг үл биелүүлсэн тохиолдол гараагүй.

Дотоодын X валютын нэгж бүхий гадаад буцалтгүй тусламжийг тухайн тайлант үеийн туршид хүчингүй болгосон. Тусгайлан заасан хөгжлийн төслүүдийн өртгийг илүү тооцсон, иймээс тухайн тайлант үеийн туршид уг донор байгууллагын амласан дүнгээс бага хэмжээний зарлага гаргасны улмаас дээрх гадаад тусламжийг хүчингүй болгосон.

**Зарцуулаагүй гадаад тусламж**

Тайлангийн өдрөөрх зарцуулаагүй гадаад тусламжийн зээл ба буцалтгүй тусламж нь нөхцлүүд хангагдсан бөгөөд цаашид тэдгээрийг үргэлжлүүлэн хангах өндөр магадлалтай, түүнчлэн иж бүрэн болох хүртэл уг төслийг үргэлжлүүлэхээр урьдчилан таамаглаж байгаа тохиолдолд одоо хөгжүүлэлтийн шатанд буй төслүүдийг санхүүжүүлэхтэй холбоотой заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заасан дүн юм.

	<b>Зээл 200Х</b>	<b>Буцалтгүй тусламж 200Х</b>	<b>Зээл 200Х- 1</b>	<b>Буцалтгүй тусламж 200Х-1</b>
Толилуулгын валютаарх эцсийн үлдэгдэл	X	X	X	X

Зарцуулаагүй тусламжийн дүнг ашиглах эсэхийг тодорхойлох буюу түүнд нөлөө үзүүлэх чухал нөхцөл, болзол нь эрүүл мэндийн болон боловсролын дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулан тусгайлан заасан дараах барилгын ажлын зорилтуудын биелэлттэй холбоотой байна: (Барилгын ажлын чухал зорилтуудыг тодорхойлох байгууллага).

**ХАВСРАЛТ 1Б**

**ЗАСГИЙН ГАЗРЫН “АБ” БАЙГУУЛЛАГА**  
**(ЭНЭ БАЙГУУЛЛАГА НЬ БАНКИН ДАХЬ ӨӨРИЙН ДАНСЫГ ХЯНАДАГ БА ГУРАВДАГЧ ТАЛЫН ХИЙСЭН**  
**ТӨЛБӨРӨӨС ӨГӨӨЖ ХҮРТДЭГ.)**  
**200Х ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН НЭГТГЭСЭН МӨНГӨН ОРЛОГО, ЗАРЛАГЫН**  
**ТАЙЛАН**

Тод-руулга	200Х			200Х-1		
	Байгуул-лагын хянаж буй мөнгөн орлого/ зарлага)	Засгийн газрын бусад байгуул-лагуудын төлбөр	Гаднын гурав-дагч талын төлбөр	Байгуул-лагын хянаж буй мөнгөн орлого/ зарлага)	Засгийн газрын бусад байгуул-лагуудын төлбөр	Гаднын гурав-дагч талын төлбөр
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>						
Зөвшөөрөгдсөн хуваарилалт / Төсвийн хуваарилалт	X	X	-	X	X	-
Бусад мөнгөн орлого	X	-	-	X	-	-
Буцалт-гүй тусламж/Тусламж	-	-	X	-	-	X
<b>Нийт мөнгөн орлого</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>						
Цалин, хөлс ба ажиллагчдын тэтгэмж	(X)	-	-	(X)	-	-
Түрээс	(X)	(X)	-	(X)	(X)	-
Капитал зарлага	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Шилжүүлэг	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлага</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
<b>Мөнгөний өсөлт / (бууралт)</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>X</b>
<b>Мөнгөний жилийн эхний үлдэгдэл</b>	<b>X</b>	<b>XГ*</b>	<b>XГ</b>	<b>X</b>	<b>XГ</b>	<b>XГ</b>
Мөнгөний өсөлт/(бууралт)	X	XГ	XГ	X	XГ	XГ
<b>Мөнгөний жилийн эцсийн үлдэгдэл</b>	<b>X</b>	<b>XГ</b>	<b>XГ</b>	<b>X</b>	<b>XГ</b>	<b>XГ</b>

\* XГ = Хамааралгүй

## НЭМЭЛТ САНХҮҮГИЙН ТАЙЛАН (СОНГОЛТООР)

Тухайлбал, төсвийн мэдээллийг хэрэв боломжтой бол сангийн гол бүлгүүдээр тодруулах, эсвэл зарлагыг гол чиг үүргээр харуулахын тулд нэмэлт санхүүгийн тайланг бэлтгэж болно. Чиг үүргээр ангилсан тайлангийн жишээг доор харуулав.

### ЧИГ ҮҮРГЭЭР ХАРУУЛСАН ЗАРЛАГЫН ТАЙЛАН

Тод-руулга (мянган валютын нэгжээр)	← 200X		→ 200X-1		
	Байгууллагын хянаж буй мөнгөн зарлага	Засгийн газрын бусад байгууллагуудын төлбөр	Байгууллагын хянаж буй мөнгөн (зарлага)	Засгийн газрын бусад байгууллагуудын төлбөр	Гаднын гуравдагч талын төлбөр
<b>ТӨЛБӨР/ЗАРЛАГА</b>					
Хөтөлбөр I	(X)	(X)	(X)	(X)	(X)
Хөтөлбөр II	(X)	(X)	(X)	(X)	(X)
Хөтөлбөр III	(X)	(X)	(X)	(X)	(X)
Хөтөлбөр IV	(X)	(X)	(X)	(X)	(X)
Бусад төлбөр/зарлага	(X)	(X)	(X)	(X)	(X)
<b>Нийт төлбөр / зарлага</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>



## **ЗАСГИЙН ГАЗРЫН “АБ” БАЙГУУЛЛАГА**

### **Санхүүгийн тайлангийн тэмдэглэл**

#### **1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

##### **Бэлтгэсэн суурь**

Санхүүгийн тайланг Мөнгөн суурьт УСНББОУС, “*Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал*”-ын дагуу бэлтгэсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тухайн тайлант үеийн туршид тууштай мөрдсөн.

##### **Тайлагнагч байгууллага**

Санхүүгийн тайланг улсын секторын байгууллагын (Засгийн газрын “АБ” байгууллагын) хувьд бэлтгэсэн. Тус санхүүгийн тайлан нь холбогдох хууль тогтоомж (Төрийн санхүүгийн хууль 20XX)-д тусгайлан заасанчлан, уг тайлагнагч байгууллагад хамаарна. Энэ нь Засгийн газрын “АБ” байгууллага болон түүний хяналтад буй байгууллагуудаас бүрддэг. Засгийн газрын “АБ” байгууллага нь “А” улсын үндэсний засгийн газрын хяналтанд байдаг.

Засгийн газрын “АБ” байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь иргэд сонгогчдод [төрлийг бичих] үйлчилгээ үзүүлэх явдал юм. Байгууллага нь банкин дахь өөрийн дансыг хянадаг. Төсвийн хуваарилалт болон бусад мөнгөн орлогыг өөрийн банкны дансанд байршуулдаг.

##### **Засгийн газрын бусад байгууллагуудаас хийсэн төлбөр**

Байгууллага нь өөрийн хяналт тавигч байгууллага (“А” Засгийн газар)-аас болон засгийн газрын бусад байгууллагуудаас түүний өмнөөс хийсэн төлбөрийн хувьд өгөөж хүртдэг.

##### **Гаднын гуравдагч талаас хийсэн төлбөр**

Байгууллага нь бараа, үйлчилгээний хувьд гаднын гуравдагч талууд (тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд гаднын байх байгууллагууд)-аас хийсэн төлбөрөөс бас өгөөж хүртдэг. Эдгээр төлбөрүүд нь тухайн байгууллагын мөнгөн орлого, зарлагыг бүрдүүлэхгүй боловч тэрхүү байгууллагад өгөөж бий болгодог. Тэдгээрийг Мөнгөн орлого, зарлагын тайлан дахь *Гуравдагч талын хийсэн төлбөр* баганад болон бусад санхүүгийн тайланд тусгасан.

##### **Толилуулгын валют**

Толилуулгын валют нь (А улсын мөнгөн тэмдэгт) юм.

#### **2. Мөнгөн хөрөнгө**

Мөнгөн хөрөнгө нь бэлэн мөнгө, харилцах данс, мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бүрддэг. Харилцах данс ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь банкин дахь дансдын

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

үлдэгдэл болон мөнгөний зах зээлийн богино хугацаат хэрэглүүрт хийсэн хөрөнгө оруулалтаас бүрдэнэ.

Байгууллагад төсөвлөн хуваарилсан дүнг уг байгууллагын банкин дахь дансанд байршуулдаг бөгөөд тухайн байгууллага нь түүнийг өөрөө хянадаг. Бүх зээлийг төв санхүүгийн байгууллага нь хариуцдаг.

Арилжааны ажил гүйлгээний мөнгөн орлогыг тухайн байгууллагын хянадаг худалдааны сангийн дансанд байршуулдаг. Нэгтгэсэн орлогод тэдгээрийг жилийн эцэст шилжүүлдэг.

Мөнгөн орлого, зарлагын тайланд тусгасан мөнгөн хөрөнгө нь дараах дүнгүүдээс бүрдэж байна:

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
Бэлэн мөнгө болон банкин дахь дансдын үлдэгдэл	X	X
Богино хугацаат хөрөнгө оруулалт	X	X
	<u>X</u>	<u>X</u>

### 3. Шилжүүлэг

Тухайн байгууллагын үйл ажиллагааны үүрэг хариуцлага ба бүрэн эрхийн дагуу шалгуур хангасан хүлээн авагчдад дүнг шилжүүлдэг.

### 4. Хяналтанд буй томоохон байгууллагууд

Байгууллага	Улс
"А" Байгууллага	X
"Б" Байгууллага	X

### 5. Зөвшөөрсөн өдөр

XXXXX-ын Сайд ноён ҮҮ нь "АБ" байгууллагын санхүүгийн тайланг нийтэд гаргахыг 200X+1 оны ...-р сарын XX өдөр зөвшөөрсөн.

**ХАВСРАЛТ 1В**

**ЗАСГИЙН ГАЗРЫН “АВ” ГАЗАР**

**(ЗАСГИЙН ГАЗАР НЬ ТӨВЛӨРСӨН НЭГ ДАНСНЫ СИСТЕМИЙГ АШИГЛАДАГ–  
БАЙГУУЛЛАГА НЬ ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗОРИУЛАН ТӨСӨВЛӨН  
ХУВААРИЛСАН ДҮНГ ХЯНАДАГГҮЙ.)**

**200Х ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН  
ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЙЛАН**

	Тод- руулга	2000Х		200Х-1	
		Төрийн сангийн данс/ нэг хяналтын данс	Гаднын гуравдагч талын төлбөр	Төрийн сангийн данс/ нэг хяналтын данс	Гаднын гуравдагч талын төлбөр
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>					
Хуваарилалт/Төсвийн хуваарилалт	2	X	-	X	-
Бусад мөнгөн орлого		X	-	X	-
Тусламж		-	X	-	X
<b>Нийт мөнгөн орлого</b>		<u><b>X</b></u>	<u><b>X</b></u>	<u><b>X</b></u>	<u><b>X</b></u>
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>					
Цалин, хөлс ба ажиллагчдын тэтгэмж		(X)	-	(X)	-
Түрээс		(X)	-	(X)	-
Капитал зарлага		(X)	(X)	(X)	(X)
Шилжүүлэг	3	(X)	(X)	(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлага</b>		<u><b>(X)</b></u>	<u><b>(X)</b></u>	<u><b>(X)</b></u>	<u><b>(X)</b></u>

## НЭМЭЛТ САНХҮҮГИЙН ТАЙЛАН (СОНГОЛТООР)

Тухайлбал, төсвийн мэдээллийг хэрэв боломжтой бол сангийн гол бүлгүүдээр тодруулах, эсвэл зарлагыг гол чиг үүргээр буюу төлбөрөөр харуулахын тулд нэмэлт санхүүгийн тайланг бэлтгэж болно. Чиг үүргээр ангилсан тайлангийн жишээг доор харуулав.

### ЧИГ ҮҮРГЭЭР ХАРУУЛСАН ЗАРЛАГЫН ТАЙЛАН

Тод- руулга	2000X		200X-1	
	Төрийн сангийн данс/ нэг хяналтын данс	Гаднын гуравдагч талын төлбөр	Төрийн сангийн данс/ нэг хяналтын данс	Гаднын гуравдагч талын төлбөр
(мянган валютын нэгжээр)				
<b>ТӨЛБӨР</b>				
Хөтөлбөр I	X	X	X	X
Хөтөлбөр II	X	X	X	X
Хөтөлбөр III	X	X	X	X
Хөтөлбөр IV	X	X	X	X
Бусад төлбөр	X	X	X	X
<b>Нийт төлбөр</b>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>

## **ЗАСГИЙН ГАЗРЫН “АВ” ГАЗАР**

### **Санхүүгийн тайлангийн тэмдэглэл**

#### **1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

##### **Бэлтгэсэн суурь**

Санхүүгийн тайланг Мөнгөн суурьт УСНББОУС, “*Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал*”-ын дагуу бэлтгэсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тухайн тайлант үеийн туршид тууштай мөрдсөн.

##### **Тайлагнагч байгууллага**

Санхүүгийн тайланг улсын секторын байгууллага болох Засгийн газрын “АВ” газрын хувьд бэлтгэсэн. Тус санхүүгийн тайлан нь холбогдох хууль тогтоомж (Төрийн санхүүгийн хууль 20XX)-д тусгайлан заасанчлан, уг тайлагнагч байгууллагад хамаарна. Энэ нь Засгийн газрын “АВ” газар юм. Засгийн газрын “АВ” газар нь “А” улсын үндэсний засгийн газрын хяналтанд байдаг.

Засгийн газрын “АВ” газрын үндсэн үйл ажиллагаа нь иргэд сонгогчдод үйлчилгээ үзүүлэх явдал юм.

Засгийн газрын АВ газар нь банкинд өөрийн дансгүй. Засгийн газар нь тухайн санхүүгийн жилийн туршид бүх газруудын гаргасан мөнгөн зарлагыг удирдах, төвлөрсөн төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус газартай холбоотойгоор энэхүү дансаар хийсэн зарлагыг Мөнгөн орлого, зарлагын тайлан дахь Төрийн сангийн данс баганад болон бусад санхүүгийн тайланд тодруулсан.

##### **Гаднын гуравдагч талаас хийсэн төлбөр**

Засгийн газрын “АВ” газар нь тухайн Засгийн газрын хувьд гаднын байх гуравдагч талуудаас тайлант үеийн туршид түүний өмнөөс худалдан авч, мөнгөн төлбөрийг төлсөн бараа, үйлчилгээнээс өгөөж хүртдэг. Тэдгээр гуравдагч талуудын хийсэн төлбөр нь уг Газрын мөнгөн орлого, зарлагыг бүрдүүлэхгүй боловч тус Газарт өгөөж бий болгодог. Тэдгээрийг Мөнгөн орлого, зарлагын тайлан дахь *Гаднын гуравдагч талын хийсэн төлбөр* баганад болон бусад санхүүгийн тайланд тусгасан.

##### **Толилуулгын валют**

Толилуулгын валют нь (А улсын мөнгөн тэмдэгт) юм.

#### **2. Төсвийн хуваарилалт**

Засгийн газрын “АВ” газарт хуваарилсан дүнг Төрийн сангийн газраас удирддаг тийм төвлөрсөн дансаар дамжуулан захиран зарцуулдаг. Тэдгээр дүнг Засгийн газрын “АВ” газар нь хянадаггүй боловч зохих баримтжуулалт ба зөвшөөрлийг танилцуулсны үндсэн дээр уг төвлөрсөн дансны захиран зарцуулагч нь тус Газрын

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

ашиг тусын төлөө захиран зарцуулдаг. Бүх зээлийг төв санхүүгийн байгууллага нь хариуцдаг. Мөнгөн орлого, зарлагын тайланд хуваарилалт/төсвийн хуваарилалт гэж тайлагнасан дүн нь “АВ” газрын ашиг тусын төлөө Төрийн сангийн газраас зарцуулсан дүн (“татан авсан” дүн) юм.

### **3. Шилжүүлэг**

“АВ” газрын үйл ажиллагааны үүрэг хариуцлага ба бүрэн эрхийн дагуу шалгуур хангасан хүлээн авагчдад дүнг шилжүүлдэг.

### **4. Зөвшөөрсөн өдөр**

ХХХХХ-ын Сайд ноён ҮҮ нь Засгийн газрын “АВ” газрын санхүүгийн тайланг нийтэд гаргахыг 200Х+1 оны ...-р сарын ХХ өдөр зөвшөөрсөн.

## **ХОЁРДУГААР ХЭСЭГ: НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ—САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА**

*Стандартын энэ хэсгийг заавал дагаж мөрдөх албагүй юм. Мөнгө суурьт тайлагналын хувьд сайшаан дэмжсэн нэмэлт тодруулгуудыг энд тусгасан. Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурьт тайлагналын шаардлагуудыг тогтоосон энэ Стандартын Нэгдүгээр хэсэгтэй үүнийг хамт унших хэрэгтэй. Ташуу хэлбэрээр бичсэн уг сайшаан дэмжсэн тодруулгуудыг тус Стандартын энэ хэсэгт энгийн хэлбэрээр бичсэн тайлбар параграфуудын хүрээнд уншвал зохино.*

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ХОЁРДУГААР ХЭСЭГ: САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

### 2.1 Сайшаан дэмжсэн нэмэлт тодруулга

#### Тодорхойлолт

2.1.1 *Дараах нэр томъёог Стандартын энэ хэсэгт доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:*

Аккруэл суурь гэдэг нь ажил гүйлгээ ба үйл явдлыг тэдгээрийн гарч тохиолдсон үед (зөвхөн мөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийг хүлээн авсан буюу төлсөн үед биш) хүлээн зөвшөөрөх нягтлан бодох бүртгэлийн суурь юм. Иймээс ажил гүйлгээ ба үйл явдлыг тэдгээрийн хамаарах тайлант үед нягтлан бодох бүртгэлд бүртгэж, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Аккруэл нягтлан бодох бүртгэлийн дагуу хүлээн зөвшөөрдөг элементүүд нь хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал юм.

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд байгууллага хяналтандаа оруулсан бөгөөд түүнээс уг байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болохоор хүлээгдэж буй нөөц юм.

Зээлийн өртөг гэдэг нь мөнгө санг зээлдэн авахтай холбоотойгоор байгууллагын гаргах хүүний болон бусад зардал юм.

Хаалтын ханш гэдэг нь тайлант үеийн эцэс дэх спот ханш юм.

Эздэд олгосон хуваарилалт гэдэг нь тухайн байгууллага өөрийн бүх буюу зарим эздэд хөрөнгө оруулалтын өгөөж эсвэл хөрөнгө оруулалтын буцаалт хэлбэрээр хуваарилсан ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи юм.

Зардал гэдэг нь эздэд олгосон хуваарилалттай холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчийг багасгах үр дүн бүхий хөрөнгийн зарлагын гүйлгээ буюу хорогдон багасалт, эсвэл өр төлбөр үүсэлт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралт юм.

Онцгой шинжтэй зүйлс гэдэг нь (энэ Стандартын зорилгын хувьд) байгууллагын ердийн үйл ажиллагаанаас эрс ялгаатай үйл явдал буюу ажил гүйлгээнээс үүсдэг, байнга буюу дахин давтагдан гарахаар хүлээгдээгүй бөгөөд тухайн байгууллагын хяналт буюу нөлөөллөөс ангид байх мөнгөн гүйлгээ юм.

Санхүүгийн хөрөнгө нь дараах аливаа хөрөнгө юм:

- (а) Мөнгө;
- (б) Өөр байгууллагаас мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авах гэрээний эрх;



(в) Санхүүгийн хэрэглүүрийг тухайн байгууллагад тааламжтай байх нөхцлөөр өөр байгууллагатай солилцох гэрээний эрх;

(г) Өөр байгууллагын өмчийн хэрэглүүр;

Өр төлбөр гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн уг байгууллагын одоогийн үүрэг бөгөөд түүнийг барагдуулсанаар эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөц тухайн байгууллагаас гарахаар хүлээгдэж байдаг.

Ердийн үйл ажиллагаа гэдэг нь өөрийн үйлчилгээ үзүүлэлт буюу худалдааны ажиллагааны нэг хэсэг байдлаар байгууллагын эрхлэн явуулдаг аливаа үйл ажиллагаа юм. Эдгээр үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, дагалдах байдлаар тухайн байгууллагын эрхэлдэг эсвэл тэднээс үүсдэг холбогдох үйл ажиллагаанууд нь ердийн үйл ажиллагаанд бас хамаарна.

Орлого гэдэг нь эздээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээ юм.

*Энэ Стандартын Нэгдүгээр хэсэгт тодорхойлсон нэр томъёог түүнд тодорхойлсонтой ижил утгаар Стандартын энэ хэсэгт хэрэглэсэн.*

## **Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи**

2.1.2 Хөрөнгө, үүн дотроо мөнгө болон бусад нөөц нь өөрийнхөө зорилтонд хүрэх арга хэрэгслээр байгууллагыг хангадаг. Байгууллагын зорилтын дагуу бараа, үйлчилгээг нийлүүлэхэд ашигладаг боловч цэвэр мөнгөн орлогын гүйлгээг шууд үүсгэн бий болгодоггүй хөрөнгүүдийг “үйлчилгээний чадавхи агуулсан” гэж ихэвчлэн нэрлэдэг. Цэвэр мөнгөн орлогын гүйлгээг бий болгоход ашигладаг хөрөнгүүдийг “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж агуулсан” гэж ихэвчлэн нэрлэдэг. Хөрөнгийг ашиглаж болох бүх зорилгыг нэгтгэн илэрхийлэхийн тулд энэ Стандартад хөрөнгүүдийн чухал шинж чанаруудыг тодорхойлох үүднээс “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи” гэсэн нэр томъёог ашигласан.

## **Тасралтгүй байх суурь**

2.1.3 *Байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх үедээ тухайн санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага бүхий этгээд нь үйл ажиллагаагаа тасралтгүй байдлаар үргэлжлүүлэн явуулах уг байгууллагын чадвар боломжийг үнэлэхийг дэмжинэ. Ийм үнэлгээг хийх үедээ тухайн санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага бүхий этгээд нь нь тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах уг байгууллагын чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал буюу нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхойгүй байдлыг мэдсэн тохиолдолд тэдгээр тодорхойгүй байдлын талаар тодруулга хийхийг дэмжинэ.*

- 2.1.4 Тасралтгүй байх төсөөлөл тохиромжтой эсэх тодорхойлолт нь бүхэлдээ засгийн газартай биш, харин тухайн бие даасан байгууллагуудад юуны өмнө хамааралтай байдаг. Бие даасан байгууллагуудын хувьд тасралтгүй байх суурь тохиромжтой эсэхийг үнэлэхдээ, санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага бүхий этгээд нь тасралтгүй байх төсөөлөл тохиромжтой гэж дүгнэх үндэслэлтэй болохын өмнө, дараах зүйлсийг харгалзан үзнэ:
- (а) Урьдчилан харж болох ирээдүйн талаархи бэлэн боломжтой байгаа бүх мэдээллийг харгалзан үзнэ. Урьдчилан харж болох ирээдүй гэдэг нь уг санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн өдрөөс хойшхи арван хоёр сарын хугацааг хамрах боловч үүгээр хязгаарлагдахгүй; ба
  - (б) Одоогийн болон хүлээгдэж буй үр дүн, зохион байгуулалтын нэгжүүдийн хувьд хийгдэх боломжит ба зарласан бүтцийн өөрчлөлт, орлогын тооцоолол буюу засгийн газрын тасралтгүй санхүүжилтийн магадлал, орлох санхүүжилтийн боломжит эх үүсвэрүүд зэрэг янз бүрийн хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байж болно.
- 2.1.5 Бизнесийн байгууллагуудад хэрэглэдэг төлбөрийн чадвар ба хөрвөх чадварт үндэслэсэн тасралтгүй байдлын нийтлэг сорил нь тааламжгүй байгааг илэрхийлэх боловч тухайн байгууллага ямартаа ч тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэдгийг бусад хүчин зүйлс харуулах тийм нөхцөл байдалтай байж болно. Тухайлбал;
- (а) Засгийн газар тасралтгүй үйл ажиллагаа явуулах эсэхийг үнэлэх үед, хэдийгээр байгууллагуудын мөнгөн зарлага нь нэлээд удаан хугацаанд мөнгөн орлогоос хэтэрсэн байж болох боловч татвар буюу хураамж ногдуулах бүрэн эрхтэй байх нь тэдгээр байгууллагуудыг тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэж үзэхэд хүргэж болох юм; ба
  - (б) Бие даасан байгууллагын хувьд, тухайн тайлант үед түүний мөнгөн гүйлгээнд хийсэн үнэлгээ нь тасралтгүй ажиллах төсөөлөл уг байгууллагад тохиромжгүй гэдгийг илэрхийлж болох юм. Гэвч тэрхүү байгууллагын тасралтгүй ажиллагааг хангах олон жилийн санхүүжилтийн хэлцлийг засгийн газартай байгуулсан байж болно.

### **Онцгой шинжтэй зүйлс**

- 2.1.6 *Байгууллага нь онцгой шинжтэй зүйл тус бүрийн шинж төрөл ба дүнг тусад нь тодруулахыг дэмжинэ. Уг тодруулгыг мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл бусад санхүүгийн тайланд буюу тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд хийж болно.*
- 2.1.7 Онцгой шинжтэй зүйлс нь байгууллагын ердийн үйл ажиллагаанаас эрс ялгаатай үйл явдал буюу ажил гүйлгээнээс үүсдэг, байнга буюу дахин давтагдан гарахаар хүлээгдээгүй бөгөөд тухайн байгууллагын хяналт буюу нөлөөллөөс ангид байна гэдгээр түүний шинж чанарыг тодорхойлдог. Иймээс онцгой шинжтэй зүйлс нь ховор, ердийн бус бөгөөд материаллаг байна.

## **Ердийн үйл ажиллагаанаас эрс ялгаатай**

2.1.8 Үйл явдал буюу ажил гүйлгээ нь байгууллагын ердийн үйл ажиллагаанаас эрс ялгаатай эсэхийг тэрхүү үйл явдлын гарч тохиолдохоор хүлээгдэж буй давтамжийг биш, харин уг байгууллагын ердийн эрхлэн явуулдаг үйл ажиллагаатай харьцуулахад тухайн үйл явдал буюу ажил гүйлгээ ямар шинж төрөлтэй байгаагаар тодорхойлдог. Байгууллага болон засгийн газрын түвшний тус тусын ердийн үйл ажиллагаа нь хоорондоо ялгаатай учраас үйл явдал буюу ажил гүйлгээ нь нэг байгууллага буюу засгийн газрын нэг түвшний хувьд онцгой шинжтэй, харин нөгөөгийн хувьд онцгой шинжтэй биш байж болно. Нийт засгийн газрын тайлагналын хувьд онцгой шинжтэй зүйлс нь туйлын ховор байдаг.

## **Ойрын ирээдүйд дахин давтагдахаар хүлээгдээгүй**

2.1.9 Ийм үйл явдал буюу ажил гүйлгээ нь тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг орчныг харгалзан үзэхэд ойрын ирээдүйд дахин давтагдахаар ул үндэслэлтэйгээр хүлээгдээгүй тийм төрлийн байдаг. Онцгой шинжтэй зүйлс нь тухайн тайлант үеийн эхэнд ихэвчлэн урьдчилан таамаглагдахааргүй тийм шинж төрөлтэй байдаг бөгөөд иймээс түүнийг төсөвт тусган оруулдаггүй. Аль нэг зүйлийг төсөвт тусган оруулах нь тухайн зүйл гарч тохиолдохыг урьдчилан харсан, иймээс онцгой шинжтэй биш гэдгийг илэрхийлдэг.

## **Тухайн байгууллагын хяналт буюу нөлөөллөөс ангид**

2.1.10 Ийм үйл явдал буюу ажил гүйлгээ нь тухайн байгууллагын хяналт буюу нөлөөллөөс ангид байдаг. Хэрэв байгууллагын шийдвэр болон тодорхойлолт нь тухайн ажил гүйлгээ буюу үйл явдал гарч тохиолдох эсэхэд ихэвчлэн нөлөөлдөггүй бол уг ажил гүйлгээ буюу үйл явдлыг тэрхүү байгууллагын хяналт болон нөлөөллөөс ангид гэж үзнэ.

## **Онцгой шинжтэй зүйлсийг тогтоох**

2.1.11 Тухайн зүйл нь онцгой шинжтэй эсэхийг уг байгууллагын үйл ажиллагааны орчин болон үйл ажиллагаа явуулдаг засгийн газрын түвшний хүрээнд харгалзан үзнэ. Тохиолдол нэг бүрийн хувьд шүүн тунгаалт хийнэ.

2.1.12 Улсын секторын зарим байгууллагууд эсвэл засгийн газрын түвшнүүдийн хувьд онцгой шинжтэй зүйлсийг хэдийгээр заавал үүсгэх албагүй боловч үүсгэж болох үйл явдал буюу ажил гүйлгээтэй холбоотой мөнгөн гүйлгээний жишээ нь:

- (а) Дүрвэгсдэд үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлагыг тухайн тайлант үеийн эхэнд урьдчилан тооцоогүй, ийм үйлчилгээ нь уг байгууллагын ердийн үйл ажиллагааны цар хүрээнд хамаарахгүй бөгөөд түүний хяналтаас ангид тохиолдолд тэрхүү үйлчилгээтэй холбоотой богино хугацаат мөнгөн гүйлгээ; ба

- (б) Байгалийн эсвэл хүний үйлдлээс шалтгаалсан гамшгийн дараа үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мөнгөн гүйлгээ. Жишээлбэл; газар хөдлөлтийн дараа орон гэргүй болсон хүмүүсийг хоргодох байраар хангах. Онцгой шинжтэй үйл явдлын шалгуурыг хангахын тулд тухайн газар хөдлөлт нь түүний гарч тохиолдсон газар зүйн бүсэд буюу уг байгууллагын үйл ажиллагаа явуулдаг бүс нутагт хэвийн хүлээгдэхээргүй тийм магнитудтай (хэмжээтэй) байх бөгөөд яаралтай тусламжийн үйлчилгээ эсвэл нөхөн сэргээх үйлчилгээ нь тэрхүү байгууллагын ердийн үйл ажиллагааны цар хүрээнд хамаарахааргүй байх ёстой. Хэрэв байгууллага нь байгалийн гамшигт өртсөн хүмүүст тусламж үзүүлэх үүрэгтэй бол ийм үйл ажиллагаатай холбоотой өртөг зардал нь онцгой шинжтэй зүйлийн тодорхойлолтыг ерөнхийдөө хангадаггүй.
- 2.1.13 Үйл ажиллагааны бүтцийн өөрчлөлт нь тухайн засгийн газрыг бүрдүүлэх улсын секторын бие даасан байгууллага болон нийт засгийн газрын байгууллагын аль алины хувьд ихэвчлэн онцгой шинжтэй зүйл болдоггүй үйл явдлын нэг жишээ юм. Тухайн зүйлийг онцгой шинжтэй гэж ангилахын тулд онцгой шинжтэй зүйлийн тодорхойлолтод дурдсан бүх гурван шалгуур хангагдах ёстой. Бүтцийн өөрчлөлт нь тухайн байгууллагын ердийн үйл ажиллагаанаас эрс ялгаатай байж болох юм. Гэвч нийт засгийн газрын түвшинд бүтцийн өөрчлөлтийг байнга хийдэг байж болно. Өөр нэг чухал зүйл бол бүтцийн өөрчлөлт нь нийт засгийн газрын байгууллагын хяналт буюу нөлөөлөлд ихэвчлэн байдаг. Бүтцийн өөрчлөлтийг тухайн засгийн газрын хяналт буюу нөлөөллөөс ангид гэж үзэж болох засгийн газрын өөр түвшин, эсвэл гаднын зохицуулагч буюу бусад гаднын бүрэн эрхэт этгээд хийсэн зөвхөн тийм нөхцөл байдал үүнд хамаарна.
- 2.1.14 Онцгой шинжтэй зүйл нэг бүрийн шинж төрөл ба дүнгийн тодруулгыг мөнгөн орлого, зарлагын тайланд, эсвэл бэлтгэж болох бусад санхүүгийн тайланд буюу тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд хийж болно. Байгууллага нь онцгой шинжтэй зүйлсийн зөвхөн нийт дүнг мөнгөн орлого, зарлагын тайланд, харин дэлгэрэнгүй мэдээллийг тэмдэглэлд тодруулахаар бас шийдвэрлэж болно.

## **Туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээ**

- 2.1.15 *Бусдын өмнөөс агент байдлаар байгууллагын туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээний үр дүн болох мөнгөн гүйлгээ болон мөнгөний үлдэгдэл нь тухайн байгууллагын хяналтаас ангид байх тохиолдолд тэдгээр мөнгөн гүйлгээ ба мөнгөний үлдэгдлийн дүн, шинж төрлийг тэрхүү байгууллага нь санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт тодруулахыг дэмжинэ.*
- 2.1.16 Бусдын өмнөөс агентын үүрэг гүйцэтгэж буй байгууллагын туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээтэй холбоотой мөнгөн гүйлгээ нь уг тайлагнагч байгууллагын хянадаг банкны дансаар дамждаггүй байж болно. Ийм тохиолдолд байгууллага нь тэрхүү туслалцаа үзүүлсэн мөнгийг өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ ашиглаж чадахгүй буюу түүнээс өөр бусад байдлаар өгөөж хүртэхгүй юм. Байгууллага нь эдгээр мөнгөн гүйлгээг

хянадаггүй, иймээс мөнгөн орлого, зарлагын тайланд, эсвэл бэлтгэж болох бусад санхүүгийн тайланд харуулсан мөнгөний нийт дүнд түүнийг оруулахгүй. Гэвч эдгээр ажил гүйлгээний гол төрлөөр харуулсан дүнгийн болон шинж төрлийн тодруулга нь тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээний талаархи ач холбогдолтой мэдээллээр хангах бөгөөд уг байгууллагын үр дүнг үнэлэхэд хамааралтай байх учраас ийм тодруулга хийхийг дэмжинэ.

2.1.17 Ийм мөнгөн орлого, зарлагыг тухайн байгууллагын хянадаг банкны харилцах дансаар дамжуулдаг тохиолдолд тэдгээрийг тус байгууллагын өөрийн мөнгөн гүйлгээ болон үлдэгдэлтэй адил байдлаар авч үзэх бөгөөд мөнгөн орлого, зарлагын тайланд харуулсан нийт дүнд тусган оруулна. Ийм мөнгөн орлого, зарлагыг цэвэр дүнгээр тайлагнахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.13(а) параграфт зөвшөөрсөн байдаг. Дараах мөнгөн орлого, зарлага болон үлдэгдлийн талаархи заавар удирдамжийг доорх 2.1.18-2.1.22-р параграфт заасан:

- (а) Засгийн газар буюу засгийн газрын байгууллагаас хянаж болох бөгөөд энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн дагуу мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнах; ба
- (б) Мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл бэлтгэж болох бусад санхүүгийн тайланд тусгахгүй боловч түүний талаар тодруулга хийхийг дэмжсэн, туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээ.

### **Орлогын цуглуулалт**

2.1.18 Улсын секторын байгууллагууд нь засгийн газар, бусад засгийн газрууд буюу засгийн газрын байгууллагуудын өмнөөс мөнгөн хөрөнгийг хянаж, эсвэл мөнгөн орлого, зарлагыг удирддаг байж болно. Жишээлбэл; засгийн газрын Татварын албыг (буюу Орлого хураах агентлагийг) банкинд өөрийн харилцах данстайгаар байгуулж, түүний үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд төсвийн хуваарилалт олгож болох юм. Татварын хууль тогтоомжийн зарим төлөв хандлагын хэрэгжүүлэлт нь тус Албаны үйл ажиллагаанд хамаарах бөгөөд засгийн газрын өмнөөс татвар хураах ажиллагааг агуулсан байж болно.

2.1.19 Татварын Алба нь түүнд төсөвлөн хуваарилсан бөгөөд түүний хянадаг банкны дансанд байршуулсан мөнгийг өөрийн үйл ажиллагааны зорилтуудад хүрэхийн тулд бүрэн эрхийн дагуу ашиглан зарцуулж, бусад этгээд тэрхүү мөнгийг ашиглах буюу өгөөж хүртэхээс сэргийлж чадах юм. Ийм тохиолдолд тус Алба нь түүний хэрэглээнд зориулан төсөвлөн хуваарилагдсан мөнгийг хянадаг. Харин татвар хураах өөрийн үйл ажиллагаагаар дамжуулан засгийн газрын өмнөөс тус Албаны цуглуулсан мөнгийг засгийн газрын тусгайлан заасан итгэмжлэлийн санд ихэвчлэн байршуулах буюу Төрийн сан болон адилтгах хэлтэс газрын захиран зарцуулдаг засгийн газрын банкны харилцах дансанд шилжүүлдэг. Энэ тохиолдолд уг цуглуулсан мөнгийг Татварын Албаны зорилтуудын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үүднээс зарцуулах, эсвэл засгийн газар буюу холбогдох эрх бүхий байгууллагын тусгайлсан төсвийн хуваарилалт болон

бусад зөвшөөрөлгүйгээр тус Албаны удирдлагын шийдвэрээр өөр бусад байдлаар ашиглаж болохгүй юм. Иймээс уг цуглуулсан мөнгийг Татварын Алба хянахгүй бөгөөд тус Албаны мөнгөн орлого буюу мөнгөний үлдэгдлийн нэг хэсэг болохгүй. Засгийн газрын шийдвэрийн үр дүнд тэрхүү цуглуулсан мөнгөний зарим хэсгийг Татварын Албаны хэрэгцээнд зориулан төсөвлөн хуваарилж эсвэл өөр бусад байдлаар хуваарилж болно. Гэвч энэ нь хяналт үүсэхэд хүргэх уг мөнгөний цуглуулалтын үр дүн биш, харин мөнгө санг тус Татварын Алба зарцуулахыг зөвшөөрсөн засгийн газрын шийдвэрийн үр дүн юм.

2.1.20 Нэг засгийн газар, тухайлбал мужийн буюу орон нутгийн засгийн газар нь өөр засгийн газрын (үндэсний засгийн газар гэх мэт) өмнөөс мөнгийг цуглуулдаг бол үүнтэй адилтгах нөхцөл байдал үүсэж болох юм. Ийм тохиолдолд тухайн засгийн газар нь мөнгө цуглуулалтын хувьд бусдын өмнөөс агентын үүргийг гүйцэтгэж байна. Бусдын агент байдлаар ажил гүйлгээг удирдан гүйцэтгэсний үр дүнд бий болсон мөнгийг тухайн цуглуулагч агентын банкны харилцах дансанд ихэвчлэн байршуулдаггүй бөгөөд иймээс уг тайлагнагч байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага буюу мөнгөний үлдэгдлийн нэг хэсгийг бүрдүүлэхгүй.

#### **“Дамжуулах” мөнгөн гүйлгээ**

2.1.21 Зарим тохиолдолд өөр байгууллагын агент байдлаар засгийн газар эсвэл засгийн газрын байгууллагын гүйцэтгэдэг орлого цуглуулах үйл ажиллагааны хувьд хийгдсэн туслалцаа үзүүлэх хэлцлийн дагуу тухайн цуглуулсан мөнгийг эцсийн хүлээн авагчид шилжүүлэхийн өмнө, тэрхүү байгууллагын банкны харилцах дансанд эхлээд байршуулдаг. Ийм ажил гүйлгээний үр дүнд үүсэх мөнгөн гүйлгээг зарим үед “дамжуулах” мөнгөн гүйлгээ гэж нэрлэдэг. Энэ тохиолдолд тухайн байгууллага нь:

- (a) Агент болохын хувьд өөрийн бүрэн эрхийн хүрээнд цуглуулсан мөнгөө ихэвчлэн богино хугацаанд хянадаг бөгөөд гуравдагч талд шилжүүлэхийн өмнө тэрхүү мөнгийг өөрийн банкны харилцах дансанд байршуулдаг;
- (б) Өөр байгууллагад шилжүүлэхээс өмнө, хүү тооцогдох дансанд байршуулсан уг дүнгээс бий болох аливаа хүүнээс ихэвчлэн өгөөж хүртдэг; ба
- (в) Уг цуглуулсан мөнгийг хууль тогтоомжийн шаардлага буюу туслалцаа үзүүлэх хэлцлийн дагуу гуравдагч талд шилжүүлэх үүрэг хүлээдэг.

Туслалцаа үзүүлэх ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн орлогыг уг тайлагнагч байгууллагын хянадаг банкны дансаар дамжуулдаг тохиолдолд тэрхүү цуглуулалтын ажиллагааны үр дүн болох мөнгөн орлого, мөнгөн шилжүүлэг, мөнгөний үлдэгдлийг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.4(a)(i) параграфт заасанчлан, тус байгууллагын мөнгөн орлого, зарлагын тайланд тусгана. Бусад талуудын өмнөөс тухайн байгууллагын туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээнээс үүссэн бөгөөд санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн мөнгөн орлого, зарлагыг цэвэр дүнгээр тайлагнаж

болно гэдгийг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.13(а) параграфт тусгайлан заасан.

### **Шилжүүлгийн төлбөр**

2.1.22 Засгийн газрын зорилтууд, хууль тогтоомж буюу бусад бүрэн эрхийн дагуу засгийн газрын байгууллага (хэлтэс газар, агентлаг буюу түүнтэй адилтгах байгууллага)-д төсөвлөн хуваарилсан дүн нь тухайлбал, ажилгүйдлийн тэтгэмж, өндөр насны буюу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, өрхийн хөнгөлөлт, нийгмийн хамгааллын болон нийгмийн бүлгүүдийн бусад тэтгэмжийн төлбөрийн хувьд гуравдагч талуудад шилжүүлэх дүнг агуулсан байж болно. Зарим тохиолдолд ийм төлбөрүүдийг тухайн байгууллагын хянадаг банкны харилцах дансаар дамжуулдаг. Ийм тохиолдолд байгууллага нь тухайн тайлант үеийн хувьд шилжүүлэгт зориулан төсөвлөн хуваарилсан мөнгийг мөнгөн орлого гэж, тэрхүү тайлант үеийн туршид шилжүүлсэн дүнг мөнгөн зарлага гэж, харин ирээдүйн шилжүүлэгт зориулан тайлант үеийн эцэст эзэмшиж буй аливаа дүнг мөнгөний эцсийн үлдэгдлийн нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрнө.

### **Мөнгөн гүйлгээний гол ангиудын тодруулга**

2.1.23 *Байгууллага нь дараах зүйлсийг мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл бусад санхүүгийн тайланд буюу тэдгээр санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулахыг дэмжинэ:*

(а) *Зарлагын шинж төрөлд эсвэл тухайн байгууллагын хүрээн дэх тэдгээр зарлагын чиг үүргийн аль тохиромжтойд үндэслэсэн ангиллыг ашиглаж, харуулсан нийт мөнгөн зарлагын болон гуравдагч талуудын төлбөрийн задаргаа шинжилгээ; ба*

(б) *Зээлийн мөнгөн орлого. Мөн тухайн зээлийн дүнг цаашид тэдгээрийн төрөл болон эх үүсвэрээр ангилж болно.*

2.1.24 2.1.23(а) параграфт сайшаан дэмжсэн дэд ангиллуудыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.12 ба 1.3.24-р параграфын шаардлагуудын дагуу мөнгөн орлого, зарлагын тайланд толилуулж болно. Мөнгөн орлого, зарлагын тайланд ангиллын өөр суурийг хэрэглэдэг тохиолдолд дээрх 2.1.23(а) параграф дахь сайшаан дэмжилтийг тусган илэрхийлэх, илүү дэлгэрэнгүй задалсан нэмэлт тодруулгыг тусдаа тайлан эсвэл тэмдэглэл хэлбэрээр харуулахыг сайшаан дэмжинэ.

2.1.25 Зарлага гаргасан гол зорилгыг тодорхойлсноор хариуцлагатай байдлыг сайжруулахын тулд мөнгөн зарлагын зүйлс болон гуравдагч талын төлбөрүүдийг цаашид дэд ангиллуудаар харуулж болно. Тухайн тайлагнагч байгууллагын тодорхой хөтөлбөр, үйл ажиллагаа буюу бусад холбогдох сегментүүдийн өртөг зардал болон өртгийн нөхөлтийг онцлон илэрхийлэхийн тулд эдгээрийг мөн дэд ангиллаар харуулж болно. Байгууллага нь энэхүү мэдээллийг дараах хоёр арга замын наад зах нь аль нэгээр толилуулахыг сайшаан дэмжинэ.

САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

- 2.1.26 Эхний аргыг зарлагын шинж төрлийн арга гэж нэрлэдэг. Мөнгөн орлого, зарлагын тайланд зарлагыг тэдгээрийн шинж төрлийн дагуу (жишээлбэл; түүхий эд материалын худалдан авалт, тээврийн зардал, цалин хөлс) нэгтгэн нийлүүлдэг бөгөөд тухайн байгууллагын хүрээн дэх янз бүрийн чиг үүргээр дахин хуваарилахгүй. Зарлагын шинж төрлийн аргыг ашиглан хийсэн ангиллын жишээг доор харуулав:

	<b>Мөнгөн зарлага</b>	<b>Гуравдагч талын төлбөр</b>
Цалин хөлс	(X)	(X)
Тээврийн зардал	(X)	(X)
Капитал зарлага	(X)	(X)
Зээлийн өртөг	(X)	(X)
Бусад	(X)	(X)
Нийт зарлага	<u>(X)</u>	<u>(X)</u>

- 2.1.27 Чиг үүргийн ангиллын арга гэж нэрлэх хоёр дахь арга нь зарлага гаргасан зорилго буюу хөтөлбөрийн дагуу зарлагыг ангилдаг. Чиг үүргүүд дэх зарлагын ангилал нь санамсаргүй тохиолдлын бөгөөд нэлээд шүүн тунгаалтыг агуулсан байж болох боловч энэхүү толилуулга нь хэрэглэгчдийг илүү их хамааралтай мэдээллээр ихэвчлэн хангадаг. Мөнгөн зарлагын чиг үүргийн ангиллын жишээг доор харуулав:

	<b>Мөнгөн зарлага</b>	<b>Гуравдагч талын төлбөр</b>
Эрүүл мэндийн үйлчилгээ	(X)	(X)
Боловсролын үйлчилгээ	(X)	(X)
Капитал зарлага	(X)	(X)
Зээлийн өртөг	(X)	(X)
Бусад	(X)	(X)
Нийт зарлага	<u>(X)</u>	<u>(X)</u>

- 2.1.28 Байгууллагын эрхлэн гүйцэтгэдэг үндсэн чиг үүрэгтэй холбоотой мөнгөн зарлагыг энэхүү аргын дагуу тусад нь харуулдаг. Дээрх жишээнд байгууллага нь эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй байна. Байгууллага нь эдгээр чиг үүрэг тус бүрийн хувьд мөнгөн зарлагын мөрийн зүйлсийг толилуулна.

- 2.1.29 Мөнгөн зарлагыг чиг үүргээр ангилж буй байгууллагууд нь зарлагын шинж төрлөөр, үүн дотроо цалин болон ажиллагчдын бусад тэтгэмжийн хувьд хийсэн төлбөрийн талаархи нэмэлт мэдээлэл тодруулахыг дэмжинэ.

- 2.1.30 Байгууллагын нийт мөнгөн орлого, үүнд: тухайн байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой ангиллын суурийг ашиглан нийт мөнгөн орлогын дэд ангиллыг тусад нь харуулахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.12-р параграфт шаардсан байдаг. Тохиромжтой ангиудаар хийх мөнгөн орлогын дэд ангилал нь тухайн хамаарах дүнгүүдийн хэмжээ, шинж



төрөл, чиг үүргээс хамаардаг. Гадаад тусламжийн болон зээлийн мөнгөн орлогын дүнгийн тодруулгаас гадна дараах дэд ангиллууд тохиромжтой байж болно:

- (а) Татварын орлого (татварын төрлүүдээр цаашид дэд ангилж болно);
- (б) Хураамж, торгууль, алданги болон зөвшөөрлийн орлого;
- (в) Арилжааны ажил гүйлгээний орлого, үүн дотроо бараа, үйлчилгээний борлуулалт ба хэрэглэгчдийн төлбөр (эдгээрийг арилжааны ажил гүйлгээ гэж ангилдаг тохиолдолд);
- (г) Гадаад тусламжийн буцалтгүй тусламж болон зээлийг олгосон зориулалт, ийм тусламж олгогч талууд ба олгосон дүн;
- (д) Бусад буцалтгүй тусламж, шилжүүлэг буюу төсвийн хуваарилалтын орлого (эх үүсвэр болон зориулалтаар ангилж болно);
- (е) Хүү болон ногдол ашгийн орлого; ба
- (ж) Бэлэг, хандивын орлого.

### **Холбоотой талуудын тодруулга**

2.1.31 *Байгууллага нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт УСНББОУС 20, “Холбоотой Талуудын Тодруулга”-аар шаардсан мэдээллийг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулахыг дэмжинэ.*

2.1.32 Аккруэл суурьт цогц УСНББОУС-ууд дахь УСНББОУС 20 нь холбоотой талууд болон тэдгээрийн холбогдох нэр томъёог тодорхойлж, хяналт үүссэн тохиолдолд холбоотой талуудын харилцааны талаар тодруулга хийх, түүнчлэн холбоотой талуудын ажил гүйлгээний талаархи зарим мэдээллийн, үүн дотроо эрх бүхий албан тушаалтны нийт цалин урамшууллын талаархи мэдээллийн тодруулга хийхийг шаарддаг.

### **Хөрөнгө, өр төлбөр болон төсвийн зэрэгцүүлэлтийн тодруулга**

2.1.33 *Байгууллага нь дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулахыг дэмжинэ:*

- (а) *Тухайн байгууллагын хөрөнгө, өр төлбөрийн талаархи мэдээлэл; ба*
- (б) *Хэрэв байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй бол төсвийн зэрэгцүүлэлт.*

2.1.34 Засгийн газрууд болон засгийн газрын байгууллагууд нь мөнгөнөөс гадна мэдэгдэхүйц хэмжээний нөөцийг хянадаг бөгөөд үйлчилгээ үзүүлэх өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ тэдгээр нөөцийг ашигладаг. Тэд өөрсдийн үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд зээл авч, мөн үйл ажиллагааныхаа явцад бусад өр болон өглөг үүсгэж, ирээдүйд капитал хөрөнгийн худалдан авалтын хувьд мөнгө зарцуулах амлалт өгч байдаг. Мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу бэлтгэж болох бусад санхүүгийн тайланд

тайлагнадаггүй. Гэвч засгийн газрууд нь өөрсдийн өр, бусад өр төлбөр болон мөнгөн бус хөрөнгийн бүртгэлийг хөтөлж, хянан үнэлж, удирддаг. Хөрөнгө, өр төлбөр, түүнчлэн тодорхой хөтөлбөр болон үйл ажиллагааны өртгийн талаархи мэдээллийн тодруулга нь хариуцлагатай байдлыг сайжруулдаг тул энэ Стандартаар түүнийг сайшаан дэмжсэн.

2.1.35 Ийм тодруулгыг хийдэг байгууллагууд нь хөрөнгө, өр төлбөрийг төрлөөр тодорхойлох, тухайлбал дараах байдлаар ангилахыг дэмжинэ:

- (a) Хөрөнгийг авлага, хөрөнгө оруулалт эсвэл үндсэн хөрөнгө гэж ангилах; ба
- (б) Өр төлбөрийг төрлөөр нь өглөг, зээл, бусад өр төлбөр гэж, эсвэл эх үүсвэрээр ангилах.

Ийм тодруулга нь эхний удаад дэлгэрэнгүй биш байж болох боловч байгууллагууд нь цаашид хөгжүүлэх ба өргөжүүлэхийг сайшаан дэмжинэ. Энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.5, 1.3.37-р параграфын шаардлагуудыг хангахын тулд эдгээр тодруулга нь санхүүгийн мэдээллийн чанарын шинжүүдтэй нийцсэн байх ёстой бөгөөд түүнийг тодорхой дүрсэлж, шууд ойлгогдохоор байвал зохино. Аккруэл суурьт УСНББОУС-ууд, үүн дотроо УСНББОУС 13 *Түрээс*, УСНББОУС 17 *Үндсэн Хөрөнгө*, УСНББОУС 19 *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө* нь хөрөнгө, өр төлбөрийн талаархи нэмэлт мэдээллийг тодруулахад байгууллагуудад ач холбогдолтой заавар удирдамжаар хангадаг.

### **Төсвийн зэрэгцүүлэлт**

2.1.36 Улсын секторын байгууллагууд нь зөвшөөрөл олгох хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр болж болох төсвийн хуваарилалт буюу төсвийн бусад бүрэн эрх хэлбэрийн төсвийн хязгаарт ихэвчлэн захирагддаг. Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилтуудын нэг нь хууль ёсоор батлагдсан төсвийн дагуу мөнгийг олж авч, ашиглан зарцуулсан эсэх талаар тайлагнах явдал юм. Зарим улс оронд, энэ шаардлагыг хууль тогтоомжид тусгадаг. Өөрсдийн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллагууд нь энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.9.1-1.9.48-р параграфын шаардлагуудыг даган мөрдөх ёстой. Санхүүгийн тайлан болон төсвийг нягтлан бодох бүртгэлийн нэг ижил сууриар бэлтгэдэг тохиолдолд бусад байгууллагууд (өөрсдийн батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй байгууллагууд) нь тухайн тайлант үеийн төсөвлөсөн дүнтэй гүйцэтгэлийг зэрэгцүүлсэн тийм тодруулгыг санхүүгийн тайландаа тусгахыг энэ Стандартаар сайшаан дэмждэг. Эдгээр бусад байгууллагуудын хувьд төсөвтэй зэрэгцүүлсэн тайлагналыг янз бүрийн арга замаар толилуулж болно. Үүнд:

- (a) Төсөвлөсөн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хувьд тусдаа багана бүхий тэмдэглэл хэлбэрийн тодруулга. Төсөв буюу төсвийн хуваарилалтаас гажсан аливаа хэлбэлзлийг харуулсан баганыг иж бүрэн байдлын зорилгоор бас толилуулж болно; ба

- (б) Төсөвлөсөн дүнгээс хэтрээгүй гэсэн тодруулга. Хэрэв аливаа төсөвлөсөн дүн буюу төсвийн хуваарилалтыг хэтрүүлсэн, эсвэл төсвийн хуваарилалт болон бусад хэлбэрийн бүрэн эрхгүйгээр зарлага гаргасан бол тухайн санхүүгийн тайлан дахь холбогдох зүйлсэд хийсэн тэмдэглэл байдлаар дэлгэрэнгүй мэдээллийг тодруулж болно.

- 2.1.37 *Гүйцэтгэл болон төсөвлөсөн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг санхүүгийн тайландаа тодруулдаг байгууллагууд нь үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийн талаархи мэдээллийг агуулсан тайлан илтгэлд үүсгэсэн харилцан лавлагааг тэдгээр санхүүгийн тайланд тусган оруулахыг дэмжинэ.*
- 2.1.38 *Олон жилийн төсөв баталдаг байгууллагууд нь тухайн төсвийн хугацааны хувьд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох харилцан хамаарлын талаархи нэмэлт тэмдэглэл тодруулга хийхийг дэмжинэ.*
- 2.1.39 Төсвийн нэмэлт мэдээллийг, үүн дотроо үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийн талаархи мэдээллийг тухайн санхүүгийн тайлангаас бусад, баримт бичигт толилуулж болно. Гүйцэтгэл болон төсөвлөсөн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг санхүүгийн тайландаа тодруулдаг байгууллагууд нь ийм баримт бичгүүд дэх, ялангуяа төсөв ба гүйцэтгэлийг уг төсвийн санхүүгийн бус мэдээ, үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийн талаархи мэдээлэлтэй холбосон харилцан лавлагааг өөрсдийн санхүүгийн тайландаа тусган оруулахыг сайшаан дэмжинэ.
- 2.1.40 Энэ Стандартын 1.9.32-р параграфт тэмдэглэсэнчлэн, байгууллагууд нь олон жилийн төсвийн бүрэлдэхүүн дэх жил тутмын төсвийг тодорхойлохдоо янз бүрийн арга хандлага баримталдаг байж болно. Олон жилийн төсөв баталдаг байгууллагууд нь олон жилийн төсөв, түүнчлэн тухайн төсвийн хугацаан дахь жил тутмын бүрэлдэхүүн төсвүүд болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох харилцан хамаарал гэх мэт асуудлуудын талаар нэмэлт тодруулга хийхийг дэмжинэ.

## **Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

- 2.1.41 *Байгууллага нь санхүүгийн тайлангийн тэмдэглэлдээ дараах зүйлсийг тодруулахыг дэмжинэ:*
- (а) *Хяналтанд буй байгууллагууд дахь өмчлөлийн хувь оролцооны хэмжээ, тэрхүү хувь оролцоо нь хувьцаа хэлбэртэй тохиолдолд эзэмшиж буй саналын эрхийн хувь хэмжээ (энэ нь хувь тэнцүүлсэн өмчлөлийн хувь оролцооноос өөр байх зөвхөн тийм тохиолдолд);*
- (б) *Хэрэв хамааралтай бол:*
- (i) *Өмчлөлийн хувь оролцоо ба/буюу саналын эрхийн 50 буюу түүнээс бага хувийг уг хяналт тавигч байгууллага эзэмшдэг аливаа хяналтанд буй байгууллагын нэрийг хяналт хэрхэн оршин буй талаархи тайлбарын хамт;*

- (ii) *Өмчлөлийн хувь оролцооны 50 хувиас илүү хэсгийг эзэмшдэг боловч хяналтанд буй байгууллага биш байх аливаа байгууллагын нэрийг яагаад хяналтгүй байгаа талаархи тайлбарын хамт; ба*
  - (v) *Хяналт тавигч байгууллагын тусдаа санхүүгийн тайлангийн хувьд тэдгээр хяналтанд буй байгууллагуудыг тайлагнахад ашигласан аргын талаархи тайлбар тодорхойлолт.*
- 2.1.42 *Нэгтгэсэн мөнгөн орлого, зарлагын тайланг толилуулдаггүй хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг яагаад бэлтгээгүй шалтгааныг, тэдгээр хяналтанд буй байгууллагуудыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа тайлагнасан суурийн хамт тодруулахыг сайшаан дэмжинэ. Нэгтгэсэн санхүүгийн тайланг хэвлэн нийтэлдэг өөрийн хяналт тавигч байгууллагын нэр болон үндсэн хаягийг уг байгууллага тодруулахыг мөн дэмжинэ.*
- 2.1.43 Хяналтанд буй байгууллагыг нэгтгэлд хамруулаагүй шалтгаанаа тодруулахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.6.20(б) параграфтаар шаардсан байдаг. Бүрэн өмчлөлт хяналтанд буй байгууллага болох хяналт тавигч байгууллага эсвэл бараг бүрэн өмчлөлт хяналтанд буй байгууллага болох хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулах шаардлагагүй гэдгийг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.6.7 ба 1.6.8-р параграфт заасан. Ийм тохиолдолд дээрх 2.1.42-р параграфт дурдсан мэдээллийн тодруулга хийхийг сайшаан дэмжинэ.

**Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны бусад нэгжүүдийн олж эзэмшилт ба данснаас хасалт**

- 2.1.44 *Байгууллага нь хяналтанд буй байгууллагууд эсвэл үйл ажиллагааны бусад нэгжүүдийн худалдан авалт ба данснаас хасалтаас үүссэн нийт мөнгөн гүйлгээг тусад нь тодруулж, толилуулахыг сайшаан дэмжинэ.*
- 2.1.45 *Байгууллага нь хяналтанд буй байгууллагууд эсвэл үйл ажиллагааны бусад нэгжүүдийн тухайн тайлант үеийн турш дахь олж эзэмшилт ба данснаас хасалтын аль алины хувьд дараах зүйл тус бүрийг нийт дүнгээр санхүүгийн тайлангийн тэмдэглэлдээ тодруулахыг дэмжинэ:*
- (a) *Олж эзэмшилт эсвэл данснаас хасалтын нийт дүн (үүн дотроо, мөнгөн болон бусад хөрөнгө);*
  - (б) *Олж эзэмшилт эсвэл данснаас хасалтын төлбөрөөс мөнгөөр барагдуулсан хэсэг; ба*
  - (в) *Олж эзэмшсэн эсвэл данснаас хассан уг хяналтанд буй байгууллага буюу үйл ажиллагааны нэгж дэх мөнгөний дүн.*
- 2.1.46 Хяналтанд буй байгууллагууд ба бусад үйл ажиллагаануудын олж эзэмшилт болон данснаас хасалтын мөнгөн гүйлгээний үр нөлөөг уг олж эзэмшсэн эсвэл данснаас хассан хөрөнгө, өр төлбөрийн дүнгийн тусдаа тодруулгын хамтаар тусад нь толилуулах нь тэдгээр мөнгөн гүйлгээг тухайн байгууллагын бусад үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн орлого, зарлагаас

ялган зааглахад тусалдаг. Олж эзэмшилт ба данснаас хасалтын аль алины үр нөлөөг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгохын тулд данснаас хасалтын мөнгөн гүйлгээний үр нөлөөг олж эзэмшилтийн мөнгөн гүйлгээнээс хасахгүй.

- 2.1.47 Худалдан авалт эсвэл борлуулалтын төлбөр байдлаар төлсөн эсвэл хүлээн авсан мөнгөний нийт дүнг уг олж эзэмшсэн эсвэл данснаас хассан мөнгийг хассан цэвэр дүнгээр мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнана.
- 2.1.48 Байгууллагын хөрөнгө, өр төлбөрийн тодруулга хийхийг 2.1.33-р параграфт сайшаан дэмжсэн. Олж эзэмшсэн эсвэл данснаас хассан уг хяналтанд буй байгууллага буюу үйл ажиллагааны нэгжийн мөнгөнөөс бусад, хөрөнгө ба өр төлбөрийг мөн гол ангилал тус бүрээр нэгтгэн товчоолсноор толилуулж болно. Ийм тодруулга хийх тохиолдолд энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.37-р параграфын шаардлагын дагуу тухайн хөрөнгө, өр төлбөрийг ойлгомжтой тодорхойлох ба тэдгээрийг хүлээн зөвшөөрсөн болон хэмжсэн суурийг тайлбарлана.

### **Хамтарсан үйлдвэр**

- 2.1.49 *Байгууллага нь тухайн тайлант үеийн турш дахь түүний мөнгөн орлого, зарлага болон уг тайлангийн өдрөөрх мөнгөний үлдэгдлийг үнэн зөв толилуулахад зайлшгүй шаардлагатай хамтарсан үйлдвэрүүдийн талаар тодруулга хийхийг сайшаан дэмжинэ.*
- 2.1.50 Улсын секторын олон байгууллагууд нь төрөл бүрийн үйл ажиллагаа явуулахын тулд хамтарсан үйлдвэрийг байгуулдаг. Эдгээр үйл ажиллагааны шинж төрөл нь арилжааны үйл ажиллагаанаас эхлээд үнэ төлбөргүй нийгмийн үйлчилгээ хүртэл өргөн хүрээтэй байдаг. Хамтарсан үйлдвэрийн нөхцлийг гэрээ буюу бусад заавал биелүүлэх хэлцлээр тогтоодог бөгөөд хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч бүрийн анхны хувь оролцоо, тэдгээр хувь оруулагч нэг бүрд хамаарах орлого буюу бусад өгөөж (хэрэв байгаа бол) болон зардлын хувь хэмжээг тусгайлан заадаг. Мөнгөн сууриар тайлагнадаг байгууллагууд нь ерөнхийдөө дараах байдлаар тайлагнана:
- (а) Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны худалдан авалт ба тухайн хамтарсан үйлдвэрийн тасралтгүй үйл ажиллагаанд зарцуулсан мөнгийг мөнгөн зарлага байдлаар; ба
  - (б) Хамтарсан үйлдвэрээс хүлээн авсан мөнгийг мөнгөн орлого байдлаар.

Хамтарсан үйлдвэрийн талаархи тодруулга нь томоохон хамтарсан үйлдвэрүүд дэх хувь оролцооны жагсаалт болон тайлбар тодорхойлолтыг агуулсан байж болно. Аккруэл суурьт цогц УСНББОУС-ууд дахь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт УСНББОУС 8, “Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцооны Санхүүгийн Тайлагнал” нь хамтарсан үйлдвэрийг эрхлэн явуулж болох янз бүрийн хэлбэр ба бүтэц, түүнчлэн

хийж болох боломжит нэмэлт тодруулгын талаархи заавар удирдамжаар хангадаг.

### **Хэт инфляцитай эдийн засгийн үеийн санхүүгийн тайлагнал**

2.1.51 Хэт инфляцитай эдийн засгийн үед санхүүгийн тайланг дахин илэрхийлэхгүйгээр тухайн орон нутгийн валютаар тайлагнах нь ач холбогдолгүй юм. Өөр өөр цаг хугацаанд, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн нэг тайлант үеийн дотор гарч тохиолдсон ажил гүйлгээ ба бусад үйл явдлуудаас үүссэн дүнгүүдийн зэрэгцүүлэлт нь төөрөгдөлд хүргэхүйц тийм хувь хэмжээгээр мөнгөний худалдан авах чадвар буурч байдаг.

2.1.52 Энэ Стандарт нь хэт инфляци үүссэн гэж үзэхэд хүргэх үнэмлэхүй дүнг тогтоодоггүй. Энэ Стандартад сайшаан дэмжсэний дагуу санхүүгийн тайланг хэзээ дахин илэрхийлэх шаардлагатай эсэхийг тогтоох нь шүүн тунгаалтын асуудал юм. Хэт инфляци үүссэн гэдгийг илэрхийлэх улс орны эдийн засгийн шинж байдлуудад дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Ард түмэн нь өөрийн эд баялгийг мөнгөн бус хөрөнгөөр эсвэл харьцангуй тогтвортой гадаад валютаар хадгалахыг эрхэмлэдэг байх. Худалдан авах чадварыг хадгалахын тулд эзэмшиж буй дотоодын валютаар нэн даруй хөрөнгө оруулалт хийдэг байх;
- (б) Ард түмэн нь мөнгөн дүнг дотоодын валютаар бус харин харьцангуй тогтвортой гадаад валютаар харгалзан үздэг байх. Үнийг мөн ийм гадаад валютаар тогтоож болох юм;
- (в) Хэдийгээр зээлийн хугацаа богино байлаа ч гэсэн зээлээр борлуулалт ба худалдан авалт нь тухайн зээлийн хугацааны туршид худалдан авах чадварт гарахаар хүлээгдэж буй алдагдлыг нөхөх үнээр тооцогдох;
- (г) Хүүний түвшин, цалин хөлс ба үнэ нь үнийн индекстэй холбогдсон байх;
- (д) Сүүлийн гурван жилийн инфляцийн хуримтлагдсан түвшин нь 100 хувьд ойртох буюу түүнээс давж гарах.

### **Санхүүгийн тайлангийн дахин илэрхийлэлт**

2.1.53 *Хэт инфляцитай эдийн засгийн валютаар тайлагнаж буй байгууллага нь дараах зүйлсийг гүйцэтгэхийг сайшаан дэмжинэ:*

- (а) *Тухайн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр өөрийн мөнгөн орлого, зарлагын тайлан болон бусад санхүүгийн тайланг дахин илэрхийлэх;*
- (б) *Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл болон түүнээс өмнөх тайлант үеүдийн аливаа мэдээллийг тухайн тайлангийн өдрөөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр дахин илэрхийлэх; ба*

- (в) *Худалдан авалтын ерөнхий чадварын өөрчлөлтийг тусгасан үнийн ерөнхий индекс ашиглах. Тухайн нэг эдийн засгийн үеийн валютаар тайлагнаж буй бүх байгууллагууд нь мөн нэг ижил индекс ашиглах хэрэгтэй.*

2.1.54 *Байгууллага нь дараах тодруулга хийхийг дэмжинэ:*

- (а) *Мөнгөн орлого, зарлагын тайлан, бусад санхүүгийн тайлан болон өмнөх тайлант үеүдийн харгалзах үзүүлэлтийг уг толилуулгын валютын худалдан авалтын ерөнхий чадварын өөрчлөлтийн хувьд дахин илэрхийлсэн бөгөөд ингэснээр эдгээр нь тухайн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлэгдсэн талаархи тодруулга; ба*
- (б) *Тухайн тайлангийн өдрөөрх үнийн индексийн тодорхойлолт ба түвшин, түүнчлэн уг тайлант үед болон өмнөх тайлант үеийн туршид энэхүү индексэд орсон өөрчлөлт.*

2.1.55 Үнэ нь улс төр, эдийн засаг, нийгмийн янз бүрийн олон хүчин зүйлсийн үр дүнд цаг хугацааны явцад өөрчлөгдөж байдаг. Эрэлт, нийлүүлэлтийн өөрчлөлт, технологийн өөрчлөлт гэх мэт тусгай хүчин зүйлс нь үнэ нэг нэгнээсээ үл хамааран мэдэгдэхүйц хэмжээгээр өсөх эсвэл буурахад хүргэж болох юм. Түүнчлэн ерөнхий хүчин зүйлс нь үнийн ерөнхий түвшний өөрчлөлтөнд, ингэснээр мөнгөний ерөнхий худалдан авах чадварын өөрчлөлтөнд хүргэж болно.

2.1.56 Хэт инфляцитай эдийн засгийн үед санхүүгийн тайланг тухайн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлснээр уг санхүүгийн тайлангийн ач холбогдол эрс нэмэгддэг. Иймээс дээрх 2.1.53 ба 2.1.54-р параграфт заасан, арга хандлага ба тодруулгыг сайшаан дэмждэг. Дахин илэрхийлээгүй санхүүгийн тайлангийн нэмэлт гүйцээлт биш, харин анхдагч толилуулга байдлаар энэхүү мэдээллийг толилуулахыг сайшаан дэмжинэ. Дахин илэрхийлэлтээс өмнөх мөнгөн орлого, зарлагын тайлан болон бусад санхүүгийн тайлангийн тусдаа толилуулгыг дэмждэггүй.

2.1.57 Мөнгөн орлого, зарлагын тайлан дахь бүх зүйлсийг тухайн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлнэ. Иймээс мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл бусад санхүүгийн тайланд тусгасан бүх дүнгүүдийг, үүн дотроо гуравдагч талын аливаа төлбөрийг тэдгээр орлого, зарлагыг анх бүртгэсэн өдрөөс хойшхи үнийн ерөнхий индексийн өөрчлөлтийг ашигласнаар дахин илэрхийлнэ.

2.1.58 Улсын секторын олон байгууллагууд нь төсөвтэй зэрэгцүүлэх боломж бүрдүүлэхийн тулд холбогдох төсвийн мэдээллийг өөрсдийн санхүүгийн тайланд тусган оруулдаг. Ийм тохиолдолд төсвийн мэдээллийг мөн энэхүү Стандартын дагуу дахин илэрхийлэхийг сайшаан дэмжинэ.

### **Зэрэгцүүлэгдэх мэдээлэл**

2.1.59 Өмнөх тайлант үеүдтэй хийх зэрэгцүүлэлт нь ач холбогдолтой бол тэрхүү зэрэгцүүлэгдэх санхүүгийн тайлангуудыг тухайн тайлант үеийн эцэст

үйлчилж буй хэмжилтийн нэгжээр толилуулахын тулд өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг үнийн ерөнхий индекс ашиглан дахин илэрхийлдэг. Өмнөх үеүдэд хамаарах тодруулсан мэдээллийг мөн тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлнэ.

### **Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

- 2.1.60 Хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлагнадаг, хяналт тавигч байгууллага нь мөн хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютуудаар тайлагнадаг, хяналтанд буй байгууллагуудтай байж болох юм. Мөнгөн орлого, зарлагын тайлан ба бусад санхүүгийн тайланг тууштай сууриар бэлтгэх ёстой бол хяналт тавигч байгууллагын бэлтгэдэг нэгтгэсэн санхүүгийн тайланд тэдгээр хяналтанд буй байгууллагуудыг тусган оруулахын өмнө, тухайн хяналтанд буй байгууллагын тайлагнадаг валютад хамаарах улс орны үнийн ерөнхий индексийг ашигласнаар тийм аливаа хяналтанд буй байгууллагуудын санхүүгийн тайланг дахин илэрхийлнэ. Ийм хяналтанд буй байгууллага нь гадаад дахь хяналтанд буй байгууллага байх тохиолдолд түүний дахин илэрхийлсэн санхүүгийн тайланг хаалтын ханшаар хөрвүүлнэ.
- 2.1.61 Хэрэв тайлант үеийн эцэс нь өөр байх санхүүгийн тайлангуудыг нэгтгэвэл, мөнгөн зүйлс эсвэл мөнгөн бус зүйлс гэдгээс үл хамааран бүх зүйлсийг тухайн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр дахин илэрхийлэх шаардлагатай.

### **Үнийн ерөнхий индексийн сонголт ба хэрэглээ**

- 2.1.62 Энэ Стандартаар сайшаан дэмжсэн арга хандлагын дагуу санхүүгийн тайлангийн дахин илэрхийлэлт нь худалдан авалтын ерөнхий чадварын өөрчлөлтийг тусгасан үнийн ерөнхий индекс ашиглахыг шаарддаг. Тухайн нэг эдийн засгийн үеийн валютаар тайлагнаж буй бүх байгууллагууд нь мөн нэг ижил индекс ашиглах хэрэгтэй гэж үздэг.
- 2.1.63 Энэ Стандартаар сайшаан дэмжсэн тодруулгууд нь хэт инфляцийн үр нөлөөг тухайн санхүүгийн тайланд тусгах суурийг тодорхой болгох зорилготой байдаг. Эдгээр нь мөн уг суурь болон холбогдох дүнгүүдийг ойлгоход ач холбогдолтой бусад мэдээллээр хангах санаа зорилготой юм.

### **Төрийн Бус Байгууллага (ТББ)-аас хүлээн авсан тусламж**

- 2.1.64 *Практик боломжтой тохиолдолд байгууллага нь төрийн бус байгууллага (ТББ)-аас хүлээн авсан тусламжийн хувьд энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.10.1-1.10.27-р параграфт заасан, зайлшгүй шаардлагатай тодруулгууд болон доорх 2.1.66-2.1.93-р параграфт дурдсан, сайшаан дэмжсэн тодруулгуудыг хийхийг дэмжинэ.*
- 2.1.65 Тайлагнагч байгууллагууд нь төрийн бус байгууллага (ТББ)-аас хүлээн авсан тусламжийн хувьд 1.10.1-1.10.27-р параграфт заасан тодруулгуудыг мөрдөх албагүй юм. Яагаад гэвэл, тэдгээр шаардлагуудыг даган мөрдөхөд хэрэгцээтэй мэдээллийг цуглуулах ба нэгтгэн нийлүүлэх өртөг зардал нь



түүний өгөөжөөс илүү байж болох юм. Гэвч ТББ-аас хүлээн авсан тусламжийн талаар 1.10.1-1.10.27-р параграфт заасан тодруулгыг доорх 2.1.66-2.1.93-р параграфт сайшаан дэмжсэн тодруулгын хамт хийх нь уг тайлагнагч байгууллага өөрийн үйл ажиллагааг дэмжихийн тулд тэдгээр байгууллагуудын тусламжаас хэр хамааралтай байгаа эсэх үнэлгээний хувьд нэмэлт орц өгөгдлөөр хангана. Иймээс практик боломжтой тохиолдолд тайлагнагч байгууллага нь ТББ-аас хүлээн авсан тусламжийн хувьд энэ Стандартад заасан тодруулгыг хийхийг сайшаан дэмжинэ.

### **Гадаад тусламж хүлээн авагчид**

2.1.66 *Байгууллага нь дараах зүйлсийг гол ангиудаар санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулахыг дэмжинэ:*

- (a) *Тухайн тайлант үеийн туршид хүлээн авсан гадаад тусламжийн зориулалт, үүнд зээл ба буцалтгүй тусламж хэлбэрээр авсан дүнгүүдийг тусдаа харуулах; ба*
- (b) *Тухайн тайлант үеийн туршид хийсэн гадаад тусламжийн төлбөрийн зориулалт.*

2.1.67 Байгууллага нь олон зорилгоор, үүн дотроо өөрийн дараах зүйлсийг дэмжихийн тулд гадаад тусламжийг хүлээн авч болно:

- (a) Эдийн засгийн хөгжил болон нийгмийн хамгааллын зорилтууд, эдгээрийг ихэвчлэн хөгжлийн тусламж гэж нэрлэдэг;
- (b) Яаралтай арга хэмжээний зорилтууд, эдгээрийг ихэвчлэн яаралтай тусламж гэж нэрлэдэг;
- (в) Төлбөрийн тэнцлийн байдал, эсвэл өөрийн валютын ханшийг хамгаалах, эдгээрийг ихэвчлэн төлбөрийн тэнцлийн тусламж гэж нэрлэдэг;
- (г) Цэргийн ба/буюу батлан хамгаалах зорилтууд, эдгээрийг ихэвчлэн цэргийн тусламж гэж нэрлэдэг; ба
- (д) Худалдааны үйл ажиллагаа, үүн дотроо экспортын зээл эсвэл экспорт/импортын банкууд буюу засгийн газрын бусад агентлагуудаас санал болгодог зээл, эдгээрийг ихэвчлэн худалдааны санхүүжилт гэж нэрлэдэг.

2.1.68 Тухайн тайлант үеийн туршид хүлээн авсан гадаад тусламжийн нийт дүнгийн тодруулга хийх, үүнд зээл ба буцалтгүй тусламж хэлбэрээр авсан дүнгүүдийг тусдаа харуулахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсэгт шаардсан байдаг. Зээл эсвэл буцалтгүй тусламж хэлбэрээр хүлээн авсан гадаад тусламжийн гол ангиудын тодруулга нь тухайн тайлант үеийн туршид олгосон тусламжийн зориулалт ба дүн, түүнчлэн тэрхүү олгосон тусламжийг уг байгууллага ирээдүйн тодорхой хугацаанд буцаан төлөх үүрэгтэй эсэхийг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог.

- 2.1.69 Тайлант үеийн туршид гадаад тусламжаар төлсөн төлбөрийн зориулалтын гол ангиудын тодруулга нь уг хүлээн авсан гадаад тусламжийн ашиглалт зарцуулалтын хувьд тухайн байгууллагын хариуцлагыг цаашид нэмэгдүүлэх юм.
- 2.1.70 *Байгууллага нь тайлант үеийн туршид гадаад тусламж олгосон тусламж үзүүлэгч нэг бүрийг болон тэдний үзүүлсэн тусламжийн дүнг тухайн олгосон валютын төрлөөр зээл ба буцалтгүй тусламж гэдгээр санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусад нь харуулахыг сайшаан дэмжинэ. Гэхдээ зарцуулаагүй байгаа аливаа дүнг үүнд оруулахгүй.*
- 2.1.71 Гадаад тусламж олгогч нэг бүрийг болон тэдний олгосон дүнг зээл ба буцалтгүй тусламж гэдгээр ангилсан тодруулга нь тусламжийн эх үүсвэрийн төрөлжилтийн хэмжээг илэрхийлдэг. Энэ нь тухайлбал, уг байгууллага тусламжийн хувьд тодорхой агентлагуудаас хамааралтай эсэх, ийм хамааралтай байдлын хэмжээ, тусламжийг олгосон валют, түүнчлэн тэрхүү тусламжийг буцалтгүй тусламж хэлбэрээр, эсвэл ирээдүйд буцаан төлөх шаардлагатай зээл хэлбэрээр олгосон эсэхийг тодорхойлоход тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тусална. Энэ параграфтаар сайшаан дэмжсэн тодруулгад тухайн тайлант үеийн туршид зарцуулаагүй байгаа дүнг оруулахгүй. Гадаад тусламжийн зарцуулаагүй дүнгийн талаархи мэдээллийг зарим нөхцөлд тодруулахыг 2.1.72-р параграфтаар сайшаан дэмжсэн.
- 2.1.72 *Тайлангийн өдрөөр зарцуулаагүй бөгөөд энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.10.18-р параграфын дагуу тодруулсан гадаад тусламжийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт тодруулахыг сайшаан дэмжинэ:*
- (а) *Зээлийн тусламж ба буцалтгүй тусламж олгогч нэг бүрийг болон тэдгээрийн тус бүрийн олгосон дүнг;*
  - (б) *Зарцуулаагүй зээлийн тусламж ба зарцуулаагүй буцалтгүй тусламжийг ашиглаж болох зориулалт;*
  - (в) *Зарцуулаагүй тусламжийг эзэмшиж байгаа буюу ашиглах боломжтой валют; ба*
  - (г) *Зарцуулаагүй зээлийн тусламж ба зарцуулаагүй буцалтгүй тусламжийн дүнд тухайн тайлант үеийн туршид орсон өөрчлөлт.*
- 2.1.73 Зарцуулаагүй гадаад тусламжийн үлдэгдлийг зарим нөхцөлд тодруулахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.10.18-р параграфтаар шаардсан байдаг. 2.1.72-р параграфтаар сайшаан дэмжсэн тодруулга нь ийм зарцуулаагүй тусламжийг ирээдүйд ашиглаж болох зориулалт, зарцуулаагүй тусламжийг эзэмшиж буй буюу ашиглах боломжтой валют, уг зарцуулаагүй зээл болон буцалтгүй тусламжийн дүнг тухайн тайлант үеийн туршид нэмэгдсэн эсвэл буурсан эсэхийг тодорхойлох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгоно.

- 2.1.74 Тайлагнагч байгууллагад тохиромжтой бол зарцуулаагүй зээл ба буцалтгүй тусламжийн эхний үлдэгдэл, тайлант үеийн туршид батлагдсан буюу өөр бусад байдлаар боломжтой болсон шинэ зээл болон шинэ буцалтгүй тусламжийн дүн, тайлант үед татан авсан буюу ашиглан зарцуулсан зээл ба буцалтгүй тусламжийн нийт дүн, тайлант үеийн туршид хүчингүй болгосон буюу хугацаа дууссан зээл ба буцалтгүй тусламжийн нийт дүн, зарцуулаагүй зээл ба буцалтгүй тусламжийн эцсийн үлдэгдэл гэх мэт асуудлуудыг уг тодруулгад зохих ёсоор тодорхойлж болно. Ийм тодруулга нь зарцуулаагүй үлдэгдлийн зөвхөн өөрчлөлтийн дүн төдийгүй тэрхүү өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийг мөн тодорхойлоход хэрэглэгчдэд тусална.
- 2.1.75 Зарцуулаагүй тусламжийн дүнгийн өөрчлөлтийн тодруулгыг тухайн байгууллагын толилуулгын валютаар хийдэг тохиолдолд энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн шаардлагуудын дагуу гадаад валютаар илэрхийлэгдсэн гадаадын тусламжийг холбогдох гүйлгээ нэг бүрийн гарсан өдрийн валютын ханшаар тэрхүү гадаад валютын дүнг үржүүлж, тэрхүү байгууллагын толилуулгын валютаар тайлагнана.
- 2.1.76 *Байгууллага нь гадаад тусламжийг ашиглах эсвэл түүний ашиглалтыг хязгаарлах эсэхийг тодорхойлох буюу түүнд нөлөө үзүүлэх уг гадаад тусламжийн хэлэлцээрийн нөхцөл, болзлыг санхүүгийн тайлангийн тэмдэглэлдээ тодруулахыг сайшаан дэмжинэ.*
- 2.1.77 Гадаад тусламжийн зарим хэлэлцээр нь уг гадаад тусламжийн ашиглалт буюу түүнийг ашиглаж болох зориулалтыг хязгаарладаг буюу тусгайлан тодорхойлдог, эсвэл бараа, үйлчилгээг худалдан авах эх үүсвэрийг хязгаарласан байдаг. Мөнгө санг тодорхой байршил дахь тусгайлан заасан байгууламжийн барилгын ажилд зориулан тодорхой орцуудыг худалдан авахад зөвхөн ашиглаж болох, эсвэл уг гадаад тусламжийн хэлэлцээрийн дагуу худалдан авах бараа, үйлчилгээ нь тусгайлан заасан улс буюу улс орнуудаас гаралтай байх ёстой гэж энэ төрлийн гадаад тусламжийн нөхцөл, болзолд тусгайлан зааж болно.
- 2.1.78 Зарим гадаад тусламжийг тогтоосон өдөр ашиглан зарцуулах эсвэл тухайн байгууллага дараах зүйлийг гүйцэтгэснээр олгодог байж болно:
- (a) Тодорхой бодлогын өөрчлөлтийг хэрэгжүүлэх гэх мэт уг гадаад тусламжийн хэлэлцээрт тусгайлан заасан ажиллагааг гүйцэтгэх; эсвэл
  - (б) Төсвийн алдагдлын зорилтот түвшин буюу эдийн засгийн өргөн хүрээтэй бусад зорилтууд гэх мэт тасралтгүй гүйцэтгэлийн зорилтуудыг биелүүлэх, эсвэл санхүүгийн секторын хөрөнгийн нөхөн сэргээлт буюу удирдлагаар хангах агентлаг байгуулах.
- 2.1.79 Гадаад тусламжийг ашиглаж болох эсэхийг тодорхойлох буюу түүнд нөлөө үзүүлэх нөхцөл, болзлын тодруулга нь тухайн гадаад тусламжийн цаг хугацааны хязгаарын хэмжээ, түүнчлэн уг байгууллага тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх ба гүйцэтгэлийн тогтоосон зорилтуудыг

биелүүлэхээс хамааралтай эсэх, мөн тэдгээр үйл ажиллагаа ба гүйцэтгэлийн зорилтууд юу болох эсэхийг илэрхийлдэг.

- 2.1.80 *Байгууллага нь дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн тэмдэглэлдээ тодруулахыг дэмжинэ:*
- (а) *Үндсэн дүн ба/буюу хүүний төлбөрийн хувьд гуравдагч талаас баталгаа гаргасан аливаа гадаад тусламжийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл, тэдгээр зээлтэй холбоотой аливаа нөхцөл ба болзол, уг баталгааны улмаас үүсэх аливаа нэмэлт нөхцөл, болзол; ба*
  - (б) *Холбогдох нөхцөл, болзлын биелэлтийн хувьд гуравдагч талаас баталгаа гаргасан гадаад тусламжийн зээл болон буцалтгүй тусламжийн дүн, нөхцөл, болзол ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэмэлт нөхцөл, болзол.*
- 2.1.81 Байгууллагын авсан гадаад тусламжийн зээлүүдийн үлдэгдэл ба тэдгээрийн хүүний төлбөрийн хувьд нийт дүнгээр эсвэл тодорхой дүн хүртэл баталгаа гаргасан байж болно. Хүлээн авагч нь үнэ тарифыг тохиролцсон томъёоны дагуу тогтоох, түүний гүйцэтгэлд гуравдагч талаас баталгаа гаргуулах гэх мэт тодорхой ажиллагааг хэрэгжүүлэх буюу тохиролцсон үр дүнд хүрэхийг уг зээлийн нөхцөл, болзлоор мөн шаардаж болох юм. Гадаад тусламжийн буцалтгүй тусламж нь мөн үүнтэй адилтгах нөхцөл, болзолтой ба гүйцэтгэлийн хувьд гуравдагч талаас баталгаа гаргуулдаг байж болно.
- 2.1.82 Гуравдагч талаас баталгаа гаргасан гадаад тусламжийн зээл болон буцалтгүй тусламжийн дүнгийн тодруулга нь уг гадаад тусламжийн хэлэлцээрээс өгөөж хүртэхийн тулд өөр байгууллагаас авдаг дэмжлэгийн хэмжээг харуулдаг. Баталгаа гаргасан гадаад тусламжийн зээл ба буцалтгүй тусламжийн нөхцөл, болзол болон уг баталгааг авахын тулд хүлээсэн аливаа нэмэлт нөхцөл, болзлын тодруулга нь тэрхүү баталгаа гаргасны үр дүн байдлаар үүсэх гүйцэтгэлийн нэмэлт шаардлагууд буюу нөхцлүүдийг илэрхийлдэг.
- 2.1.83 *Байгууллага нь гадаад тусламжийн зээл, буцалтгүй тусламж эсвэл баталгаатай холбоотой, үл биелүүлсэн бусад гол чухал нөхцөл, болзлыг тийнхүү үл биелүүлсэний үр дагаврын хамт санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулахыг сайшаан дэмжинэ.*
- 2.1.84 Үл биелүүлэлт нь уг тусламжийг хүчингүй болгох буюу өмнө олгосон тусламжийг буцаах үүрэг хүлээлгэх тийм үр дагавартай тохиолдолд даган мөрдөөгүй тэдгээр гол чухал нөхцөл, болзлыг санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт тодруулахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.10.25-р параграфт шаардсан байдаг. Даган биелүүлэх шаардлагатай бусад гол чухал нөхцөл, болзол, түүнчлэн зарим горимын шинжтэй нөхцөл, болзлыг гадаад тусламжийн хэлэлцээрт тусгасан байж болно. Эдгээр бусад гол чухал нөхцөл, болзлыг үл биелүүлснээр тухайн зөрчлийг засварлах хүртэл

уг ашиглаж эсвэл ирээдүйд бэлэн боломжтой байлгаж болох мөнгө сангийн дүнг бууруулах болон хугацааг өөрчлөх үр дагавартай байж болох юм.

- 2.1.85 Эдгээр даган биелүүлээгүй бусад гол чухал нөхцөл, болзлын тогтоолт нь мэргэжлийн шүүн тунгаалт шаардах магадлалтай байдаг. Байгууллагын тухайн тодорхой нөхцөл байдлын хүрээнд, санхүүгийн тайлангийн чанарын шинжүүдийг харгалзснаар ийм шүүн тунгаалтыг хийдэг. Нөхцөл, болзлын үл биелүүлэлт нь тухайн байгууллагын ирээдүйн үйл ажиллагааг дэмжих бэлэн боломжтой мөнгө сангийн дүн буюу хугацаанд нөлөөлөх тийм нөхцөл, болзол байх магадлалтай юм.
- 2.1.86 *Байгууллага нь гадаад тусламжийн төлөгдөөгүй өрийн буцаан төлөлтийн нөхцөл, болзлын хураангуй мэдээллийг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулахыг сайшаан дэмжинэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн өрийг ирээдүйд барагдуулах төлбөрийн тодруулгыг хийдэг тохиолдолд тухайн байгууллага нь тэдгээр төлбөрийн гадаад валютын дүнг хаалтын ханшаар үржүүлснээр өөрийн толилуулын валютаар тайлагнахыг дэмжинэ.*
- 2.1.87 Төлбөр хойшлуулах хугацаа, хүүний хувь, одоо өрийг барагдуулах төлбөр, ирээдүйд өрийг барагдуулах төлбөр, зээлийн үлдсэн хугацаа, өрийг барагдуулах төлбөрийн валют, үндсэн дүнгийн буцаан төлөлтийн шаардлагууд (үндсэн дүнгийн буцаан төлөлтийг тухайн зээлийн хугацааны эцэс буюу ирээдүйн бусад тодорхой өдөр хүртэл хойшлуулсан тохиолдолд) болон буцаан төлөлтийн бусад чухал нөхцөл гэх мэт асуудлуудтай холбоотой нөхцөл, болзлыг гадаад тусламжийн өрийн хэлэлцээрт тусгадаг.
- 2.1.88 Өрийг барагдуулах төлбөр нь тухайн байгууллагын хувьд мэдэгдэхүйц дүнтэй мөнгөн зарлага байж болох бөгөөд одоогийн болон нэмэлт үйл ажиллагааг санхүүжүүлэх бэлэн боломжтой мөнгөнд нөлөө үзүүлнэ. Гадаад тусламжийн төлөгдөөгүй өрийг буцаан төлөх нөхцөл, болзлын тодруулга нь өрийг (үндсэн дүн, хүү болон үйлчилгээний хураамж) барагдуулах төлбөр хэзээ эхлэх, үндсэн дүнгийн, хүүний болон үйлчилгээний хураамжийн өглөгийг тодорхойлох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгодог.
- 2.1.89 Буцаан төлөлтийн нөхцөл, болзлын талаархи мэдээллийн тодруулга нь тухайлбал, хувьсах хүүтэй өрийн хувьд хэрэглэх хүүний түвшний тооцоолол хийхийг шаардаж болох юм. Хаалтын өдрөөрх зохих хүүний хувь хэмжээг ихэвчлэн лавлагаа болгосноор уг тооцоолсон хүүний түвшинг тодорхойлдог. Байгууллага нь тооцоолол бүхий тодруулгыг толилуулах сонголт хийсэн бөгөөд тухайн санхүүгийн тайлангийн хувьд зөв ойлголт өгөхөд шаардлагатай бол уг тооцооллыг хийхдээ сонгож, мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.30-1.3.37-р параграфын шаардлагуудын дагуу тодруулна.
- 2.1.90 *Байгууллага нь бараа, үйлчилгээ хэлбэрээр хүлээн авсан гадаад тусламжийн үнэ цэнийг санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт тусад нь тодруулахыг сайшаан дэмжинэ.*

- 2.1.91 Гадаад тусламжийн хэлэлцээрийн дагуу мэдэгдэхүйц хэмжээний нөөцийг бараа, үйлчилгээ хэлбэрээр хүлээн авч болно. Авто тээврийн хэрэгсэл, компьютер, бусад тоног төхөөрөмж гэх мэт шинэ болон хуучин барааг гадаад тусламжийн хэлэлцээрийн дагуу тухайн байгууллагад шилжүүлснээр ийм тохиолдол үүсдэг. Гадаад тусламжийн хэлэлцээрийн дагуу иргэдэд тараах зорилгоор засгийн газарт хүнсний туслалцаа үзүүлэх үед мөн ийм тохиолдол гардаг. Зарим хүлээн авагчдын хувьд, бараа буюу үйлчилгээ нь гадаад тусламж хүлээн авах гол хэлбэр байж болох юм.
- 2.1.92 Бараа, үйлчилгээ байдлаар хүлээн авсан гадаад тусламжийн үнэ цэнийн тодруулга нь тухайн тайлант үеийн туршид хүлээн авсан гадаад тусламжийн нийт хэмжээг илүү сайн олгоход санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тусалдаг. Гэвч зарим тохиолдолд болон зарим хүлээн авагчдын хувьд ийм бараа, үйлчилгээний үнэ цэнийг тодорхойлох нь төвөгтэй, цаг хугацаа их зарцуулсан, өртөг зардалтай үйл явц байж болно. Тухайн бараа, үйлчилгээний дотоодын зах зээлийн үнийг шууд тодорхойлж чадахгүй, нийлүүлсэн бараа, үйлчилгээг олон улсын зах зээлд арилждаггүй буюу яаралтай тусламжийн хувьд ихэвчлэн олгодог гэх мэт өвөрмөц онцлогтой бол ялангуяа ийм тохиолдол үүсдэг.
- 2.1.93 Бараа, үйлчилгээний үнэ цэнийг тодорхойлох суурийг энэ Стандартад тусгайлан заагаагүй. Иймээс тэдгээрийн үнэ цэнийг тухайн хөрөнгийг хүлээн авагчид шилжүүлэх үеийн биет хөрөнгийн элэгдэл тооцсон түүхэн өртгөөр, эсвэл хүнсний хувьд гадаад тусламжийн агентлагийн төлсөн үнээр тодорхойлж болох юм. Шилжүүлэгчийн удирдлагын, эсвэл хүлээн авагчийн, эсвэл гуравдагч талын үнэлгээнд үндэслэн үнэ цэнийг бас тодорхойлж болно. Бараа, үйлчилгээ хэлбэрийн гадаад тусламжийн үнэ цэнийг тодруулдаг тохиолдолд уг үнэ цэнийг тодорхойлдог суурийг тодруулахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.10.21-р параграфээр шаардсан байдаг. Бодит үнэ цэнэ гэж илэрхийлдэг тохиолдолд энэ нь бодит үнэ цэнийн тодорхойлолттой нийцдэг өөрөөр хэлбэл, зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийг арилжиж, өр төлбөрийг барагдуулж болох дүн байна.

## **2.2 Нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурьт шилжихээр төлөвлөж буй засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагууд**

### **Мөнгөн орлого, зарлагын тайлангийн толилуулга**

- 2.2.1 *Нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурьт шилжихээр төлөвлөж буй байгууллага нь мөнгөн орлого, зарлагын тайлангаа Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт 2 (УСНББОУС 2) “Мөнгөн Гүйлгээний Тайлан”-гаар шаардсантай ижил загвараар толилуулахыг сайшаан дэмжинэ.*
- 2.2.2 УСНББОУС 2 нь мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны гэж ангилах заавар

удирдамжаар хангадаг бөгөөд эдгээр ангиудыг уг тайланд тус тусад нь тайлагнах мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэх шаардлагуудыг агуулсан байдаг. УСНББОУС 2-ын гол төлөв хандлагуудын тойм болон тус Стандартын дагуух санхүүгийн тайлагналд түүнийг мөрдөх талаархи заавар удирдамжийг Хавсралт 3-д тусгасан. УСНББОУС 2-оор шаардсанаас бусад, нэмэлт мэдээллийн тодруулга хийхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн. Мөнгөн орлого, зарлагын тайлангийн толилуулгад УСНББОУС 2-ын загварыг баримталдаг байгууллагууд нь энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт заасан, нэмэлт тодруулга хийхийг мөн дэмжинэ.

### **Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн цар хүрээ – Эдийн засгийн нэгдмэл байгууллагыг үл хамруулах**

- 2.2.3 Байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-д заасан нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг мөрддөг тохиолдолд ойрын ирээдүйд худалдан борлуулах зөвхөн тийм санаа зорилготойгоор тухайн хяналтанд буй байгууллагыг худалдан авч, эзэмшиж байгаа учраас түр зуур хяналтандаа байлгах тийм байгууллагуудыг нэгтгэхгүй. Жишээлбэл; үндэсний засгийн газар нь хяналтанд буй байгууллага дахь өөрийн хувь оролцоог орон нутгийн засаг захиргаанд шилжүүлэх санаа зорилготой байгаа тохиолдолд түр зуурын хяналт үүсэж болох юм.
- 2.2.4 Мөнгөн суурийн дагуу бэлтгэдэг, нэгтгэсэн санхүүгийн тайлангаас ийм байгууллагуудыг оруулахгүй хасахаар энэ Стандартын Нэгдүгээр хэсэгт заагаагүй. Яагаад гэвэл:
- (а) Зөвхөн түр зуур хянаж буй байгууллагын мөнгийг тэрхүү түр зуур хянаж байгаа хугацаанд тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын үр өгөөжийн төлөө ашиглаж болох юм; ба
  - (б) Аккруэл суурийн дагуу шаардлагатай байж болох нэгтгэлийн боломжит нарийн төвөгтэй тохируулга нь мөнгөн суурийн хувьд үүсдэггүй.
- 2.2.5 Аккруэл суурьт УСНББОУС-ын дагуу мөрдөх энэхүү нэгтгэлээс чөлөөлөгдөхийн тулд тухайн хяналт тавигч байгууллага нь түр зуур хяналтанд буй уг байгууллагыг данснаас хасах буюу цаашид хянахгүй гэсэн албан ёсны төлөвлөгөөний хувьд илт тодорхой хариуцлага хүлээдэг байх ёстой. Нэгээс олон тооны дараалсан тайлангийн өдөр нэгтгэлээс чөлөөлөгдөхийн тулд тухайн хяналт тавигч байгууллага нь түр зуур хяналтанд буй уг байгууллагыг данснаас хасах буюу цаашид хянахгүй гэсэн байнгын санаа зорилгоо батлан харуулах ёстой. Байгууллага нь данснаас хасах буюу цаашид хянахгүй гэсэн албан ёсны төлөвлөгөөтэй бөгөөд уг төлөвлөгөөнөөс татгалзах бодит боломжгүй тохиолдолд ийм илт тодорхой хариуцлага хүлээдэг.
- 2.2.6 Аккруэл суурьт шилжихээр бэлтгэж буй байгууллага нь аккруэл ба мөнгөн суурьт УСНББОУС-уудын нэгтгэлийн шаардлагуудын энэхүү ялгаатай байдлыг мэддэг байх бөгөөд нэгтгэсэн мөнгөн орлого, зарлагын тайланд

## САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

тусгасан хяналтанд буй аливаа байгууллагын хувьд хяналт түр зуурын эсэхийг тодорхойлох шаардлагатай.



**Хавсралт 2****Энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн зарим тодруулгын үлгэрчилсэн жишээ**

Энэхүү Хавсралт нь зөвхөн үлгэрчилсэн жишээ юм. Хавсралтын зорилго нь сайшаан дэмжсэн зүйлсийг хэрхэн мөрдөхийг үлгэрчлэн харуулах ба тэдгээрийн утгыг тодруулахад туслах явдал юм.

**“АБВ” байгууллагын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс****Туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээ (2.1.15-р параграф)**

Туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээ нь засгийн газар болон засгийн газрын тодорхой этгээдийн өмнөөс агент байдлаар уг байгууллагын туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээний үр дүн болох мөнгөн гүйлгээнээс бүрддэг. Агентын бүрэн эрхийн хүрээнд цуглуулсан бүх мөнгийг нэгтгэсэн орлогын санд ба/буюу итгэмжлэлийн сангийн (дансны нэр) аль тохиромжтойд байршуулдаг. Байгууллага нь эдгээр дансыг хянадаггүй бөгөөд түүнд байршуулсан мөнгийг засгийн газрын холбогдох этгээдийн тусгай зөвшөөрөлгүйгээр ашиглаж болохгүй.

(мянган валютын нэгжээр)	Ажил гүйлгээний шинж төрөл	200X	200X-1
Засгийн газар/засаглах эрхийн өмнөөс цуглуулсан мөнгө “И Эф” агентлаг	Татварын цуглуулалт	X	X
	Ашиглалтын үйлчилгээний төлбөрийн цуглуулалт	X	X
Холбогдох байгууллагуудад шилжүүлсэн мөнгө		X (X)	X (X)
		-	-

**Холбоотой талуудын ажил гүйлгээ (параграф 2.1.31)**

“АБВ” байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд (УСНББОУС 20, “Холбоотой Талуудын Тодруулга”-д тодорхойлсноор) нь Сайд, удирдах зөвлөлийн гишүүд, дээд түвшний удирдлагын бүлгийн гишүүд юм. Удирдах зөвлөл нь нь “А” засгийн газраас томилсон гишүүдээс бүрддэг. Гүйцэтгэх захирал болон санхүүгийн албаны дарга нь удирдах зөвлөлийн хуралд оролцдог боловч удирдах зөвлөлийн гишүүд биш юм. “АБВ” байгууллага нь Сайдад цалин урамшуулал олгодоггүй. Удирдах зөвлөлийн гишүүдийн нийт цалин урамшуулал ба энэхүү ангиллын хүрээнд цалин урамшуулал авдаг, бүтэн цагтай адилтгах сууриар тодорхойлсон гишүүдийн тоо дараах байдалтай байна:

Нийт цалин урамшуулал            АХ сая.  
Хүмүүсийн тоо                        АУ хүн.

САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

Дээд түвшний удирдлагын бүлэг нь уг байгууллагын гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга болон хэлтсийн дарга нараас бүрддэг. Дээд түвшний удирдлагын бүлгийн гишүүдийн нийт цалин урамшуулал ба энэхүү ангиллын хүрээнд цалин урамшуулал авдаг, бүтэн цагтай адилтгах сууриар тодорхойлсон менежерүүдийн тоо дараах байдалтай байна:

Нийт цалин урамшуулал            AP сая.  
Хүмүүсийн тоо                        AQ хүн.

**“X” Засгийн газрын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс**

***Хөрөнгө, өр төлбөр (2.1.33(а) параграф)***

*Үндсэн хөрөнгө*

Засгийн газар нь өөрийн үндсэн хөрөнгийн гол ангиудыг тодорхойлох ба үнэ цэнийг тогтоох ажиллагааг эхлүүлсэн. Тэдгээр хөрөнгийг түүхэн өртгөөр эсвэл үнэлсэн дүнгээр илэрхийлдэг. Үнэлгээг хараат бус мэргэжлийн үнэлгээчин гүйцэтгэсэн. Хөрөнгийн ангилал тус бүрийн хувьд хэрэглэсэн үнэлгээний суурь нь дараах байдалтай байна:

<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>Өртөг</b>
Газар	Одоогийн үнэ цэнэ
Барилга	Өртөг эсвэл зах зээлийн үнэ цэнэ

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
Машин, тоног төхөөрөмж	X	X
Газар ба барилга		
Хотын хязгаарын доторх үл хөдлөх хөрөнгө	X	X
Барилга, өртгөөр	X	X
Барилга, үнэлгээгээр	X	X
	X	X

*(“X” Засгийн газрын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс: Хөрөнгө, өр төлбөр (2.1.33(а) параграфын үргэлжлэл)*

САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

Зээл

Засгийн газрын зээлийг доор жагсаан харуулав:

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
Жилийн эхний үлдэгдэл	X	X
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>		
Дотоодын арилжааны санхүүгийн байгууллага	X	X
Гадаадын арилжааны санхүүгийн байгууллага	X	X
Хөгжлийн банкууд ба адилтгах зээлдүүлэгч агентлагууд	X	X
<b>Нийт зээл</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>БУЦААН ТӨЛӨЛТ</b>		
Дотоодын арилжааны санхүүгийн байгууллага	(X)	(X)
Гадаадын арилжааны санхүүгийн байгууллага	(X)	(X)
Хөгжлийн банкууд ба адилтгах зээлдүүлэгч агентлагууд	(X)	(X)
<b>Нийт буцаан төлөлт</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
Жилийн эцсийн үлдэгдэл	X	X

САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

("Х" Засгийн газрын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс, үргэлжлэл)

**Байгууллага нь өөрийн төсвөө олон нийтэд нээлттэй манилцуулдаггүй үеийн төсвийн зэрэгцүүлэлт (2.1.33 (б) параграф)**

(мянган валютын нэгжээр)	Гүйцэтгэл	Төсөвлө- сөн дүн	Хэлбэлзэл
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>			
<i><b>Татвар</b></i>			
Орлогын татвар	X	X	X
Нэмэгдсэн өртгийн албан татвар	X	X	(X)
Үл хөдлөх хөрөнгийн татвар	X	X	X
Бусад татвар	X	X	(X)
	X	X	X
<i><b>Туслалцааны хэлэлцээр</b></i>			
Олон улсын агентлаг	X	X	-
Бусад буцалтгүй тусламж ба туслалцаа	X	X	-
	X	X	-
<i><b>Зээл</b></i>			
Зээлийн мөнгөн орлого	X	X	(X)
<i><b>Капитал мөнгөн орлого</b></i>			
Үндсэн хөрөнгийн данснаас хасалтын мөнгөн орлого	X	X	X
<i><b>Худалдаа арилжааны үйл ажиллагаа</b></i>			
Худалдаа арилжааны үйл ажиллагааны мөнгөн орлого	X	X	X
<i><b>Бусад мөнгөн орлого</b></i>			
	X	X	X
<b>Нийт мөнгөн орлого</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>			
<i><b>Үйл ажиллагаа</b></i>			
Цалин, хөлс ба ажиллагчдын тэтгэмж	(X)	(X)	(X)
Хангамжийн болон хэрэглээний зүйлс	(X)	(X)	(X)
	(X)	(X)	(X)
<i><b>Шилжүүлэг</b></i>			
Буцалтгүй тусламж	(X)	(X)	-
Бусад шилжүүлгийн төлбөр	(X)	(X)	-
	(X)	(X)	-
<i><b>Капитал зарлага</b></i>			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт/барьж байгуулалт	(X)	(X)	(X)
Санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалт	(X)	(X)	-
	(X)	(X)	(X)
<i><b>Зээл ба хүүний буцаан төлөлт</b></i>			
Зээлийн буцаан төлөлт	(X)	(X)	-
Хүүний буцаан төлөлт	(X)	(X)	-
	(X)	(X)	-
<i><b>Бусад төлбөр</b></i>			
	(X)	(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлага</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
<b>ЦЭВЭР МӨНГӨН ОРЛОГО/(ЗАРЛАГА)</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

**“XYZ” байгууллагын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс**

***Хяналтанд буй байгууллагууд (2.1.41, 2.1.44, 2.1.45-р параграфууд)***

“XYZ” байгууллага нь бусад байгууллагуудын үйл ажиллагаанаас өгөөж хүртэхийн тулд тэдгээрийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг удирдан чиглүүлэх бүрэн эрхтэй байдаг. Тэдгээр нь хяналтанд буй байгууллагууд юм. Хяналтанд буй бүх байгууллагуудыг уг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгадаг. (Хяналтанд буй томоохон байгууллагуудын жагсаалтыг тодруулахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.6.20(а) параграфт шаардсан байдаг.)

Засгийн газрын байгууллагуудын хяналт нь дүрэм эсвэл бүрэн эрх олгох бусад хууль тогтоомжоор үүсдэг. Улсын Үйлдвэрийн Газруудын хяналт нь дүрмээр үүсдэг бөгөөд “В” ба “Г” аж ахуйн нэгжийн хувьд өмчлөлийн хувь оролцоогоор хяналтыг тогтоодог. “Д” аж ахуйн нэгжийн өмчийн дийлэнх хэсгийг хувийн хөрөнгө оруулагчдад борлуулсан боловч “XYZ” байгууллага нь хууль тогтоомжийн бүрэн эрхээр дамжуулан “Д” аж ахуйн нэгжийн хяналтыг хадгалж үлдсэн.

<b>Аж ахуйн нэгж</b>	<b>Өмчлөлийн хувь оролцоо (%)</b>	<b>Саналын эрх (%)</b>
“Д” аж ахуйн нэгж	XX	XX

*Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны нэгжүүдийн худалдан авалт*

<b>Худалдан авсан аж ахуйн нэгжүүдийн нэрс</b>	<b>Олж эзэмшсэн өмчлөлийн хэмжээ %</b>	<b>Худалдан авалтын төлбөр (мянган валютын нэгж)</b>	<b>Худалдан авалтын төлбөрөөс мөнгөөр төлсөн дүн (мянган валютын нэгж)</b>	<b>Олж эзэмшсэн мөнгөний үлдэгдэл (мянган валютын нэгж)</b>
“В” аж ахуйн нэгж	XX	X	X	X
“Г” аж ахуйн нэгж	XX	X	X	X
		<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

*(“XYZ” байгууллагын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс, үргэлжлэл)*

САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны нэгжүүдийн данснаас хасалт

Данснаас хассан аж ахуйн нэгжийн нэр	Данснаас хассан өмчлөлийн хэмжээ %	Данснаас хасалтын төлбөр (мянган валютын нэгж)	Данснаас хасалтын төлбөрөөс мөнгөөр авсан дүн (мянган валютын нэгж)	Данснаас хассан мөнгөний үлдэгдэл (мянган валютын нэгж)
“Е” аж ахуйн нэгж	XX	X	X	X

Томоохон хамтарсан үйлдвэрүүд (2.1.49-р параграф)

Хамтарсан үйлдвэрийн нэр	Үндсэн үйл ажиллагаа	Үр дүн дэх хувь оролцоо	
		200X %	200X-1 %
Бүсийн Усны Зөвлөл	Усан хангамж	XX	XX
Бүсийн Эрчим Хүчний Зөвлөл	Ашиглалтын үйлчилгээ үзүүлэлт	XX	XX

**“Б” Засгийн газрын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс**

**Мөнгөн суурьт хоёр жилийн төсөв — 200X оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жил (2.1.38-р параграф)**

	Хоёр жилийн анхны төсөв	1 дэх жилийн зорилтот төсөв	1 дэх жилийн зарварласан төсөв	Зэрэгцүүлэгдэх сууриарх 1 дэх жилийн гүйцэтгэл	2 дахь жилд ашиглах боломжтой үлдэгдэл	2 дахь жилийн зорилтот төсөв	2 дахь жилийн засварласан төсөв	Зэрэгцүүлэгдэх сууриарх 2 дахь жилийн гүйцэтгэл	Төсвийн хугацаан дахь төсөв ба гүйцэтгэлийн зөрүү*
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>									
Татвар	X	X	X	X	X	X	X	X	X
Тусалцааны хэлэлцээр	X	X	X	X	X	X	X	X	X
Зээлийн мөнгөн орлого	X	X	X	X	X	X	X	X	X
Үндсэн хөрөнгө данснаас хасалтын мөнгөн орлого	X	X	X	X	X	X	X	X	X
Бусад орлого	X	X	X	X	X	X	X	X	X
<b>Нийт мөнгөн орлого</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>									
Эрүүл мэнд	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Боловсрол	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Нийтийн хэв журам, аюулгүй байдал	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Нийгмийн хамгаалал	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Батлан хамгаалах	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Орон сууц, нийтийн аж ахуй	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Амралт зугаалга, соёл, шашин	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Эдийн засаг	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Бусад	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлага</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
<b>ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

\* Энэ баганыг оруулах албагүй. Гэвч анхны эсвэл тодотгосон гэдгийг зохих ёсоор тодорхойлсон төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зөрөгцүүлэлтийг тусган оруулж болох юм.

**“В” Засгийн газрын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс**

**Төрийн Бус Байгууллага (ТББ)-аас үзүүлсэн тусламж (2.1.64-р параграф)**

ТББ-уудаас үзүүлсэн тусламжийг Мөнгөн орлого, зарлагын тайлан дахь “Бусад буцалтгүй тусламж ба туслалцаа”-ны дүнд тусган оруулсан. Тайлант үеийн туршид ТББ-уудаас толилуулгын валютаар хүлээн авсан тусламжийн дүнг доор харуулав:

	200X		200X-1	
	Мөнгөн орлого	Гуравдагч талын төлбөр	Мөнгөн орлого	Гуравдагч талын төлбөр
<b>Буцалтгүй тусламжийн сан</b>	X	X	X	-
<b>Зээлийн сан</b>	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	-

Тусламжийг дараах зориулалтаар ашиглана гэдгийг тусгайлан заасан хэлэлцээрийн дагуу ТББ-уудаас хүлээн авсан:

	Хөгжлийн тусламж		Яаралтай тусламж		Бусад		Бүгд	
	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1
<b>ТББ 1</b>	X	X	-	-	-	X	X	X
<b>ТББ 2</b>	-	-	X	-	-	-	X	-
<b>ТББ 3</b>	X	X	X	-	-	-	X	X
<b>Нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	-	-	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Ам доллар</b>	X	X	X	X	-	X	X	X
<b>Евро</b>	X	X	X	-	-	-	X	X
<b>Иен</b>	-	-	X	X	-	-	X	X

Гадаад тусламжийг олгосон валютаар доор харуулав:

- ТББ 1 – Ам.доллараар ҮҮҮ дүн, бусад валютаар (валютыг дурдах) X дүн.
- ТББ 2 – Еврогоор ҮҮҮ дүн.
- ТББ 3 – Иенээр ҮҮҮ дүн.

Тусгайлан заасан зориулалтын дагуу тусламжийг бүрэн ашигласан.

1, 2, 3 дахь ТББ-ууд нь хэрэгцээ гарсан бөгөөд өөрсдийн нөөц тохиромжтой бол яаралтай тусламжийг байнга үзүүлэх санаа зорилготой байгаа гэдгээ илэрхийлсэн боловч заавал биелүүлэх бичгэн хэлцэлд тусламжийн хэмжээг заагаагүй. Хэрэгцээ шаардлагын үнэлгээ болон байнгын тусламж үзүүлэх ТББ нэг бүрийн чадавхи боломжид үндэслэн тусламжийн хэмжээг тодорхойлно.

“ZZZ” бүсэд болсон газар хөдлөлтийн хохирогчдод туслалцаа үзүүлэхийн тулд ТББ 1 нь 200X оны туршид эрүүл мэндийн баг болон эмнэлгийн тоног төхөөрөмжөөр



## САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

хангасан. Мөн ТББ 2 нь түр хоргодох байр, хоол хүнс, хувцсаар хангасан. Уг хүлээн авсан бараа, үйлчилгээний үнэ цэнийг дотоод валютын ХХ нэгж гэж тооцоолсон. Үзүүлсэн тусгай мэргэжлийн яаралтай тусламжийн үнэ цэнийг тухайн холбогдох ТББ-уудаас гаргасан өртөг зардлын тооцоололд үндэслэн тодорхойлсон.

Буцалтгүй тусламжийг цуцлахад хүргэх нөхцөл, болзлыг үл биелүүлсэн тохиолдол гараагүй.

200Х болон 200Х–1 онд ТББ-уудаас хүлээн авсан тусламжаас зарцуулаагүй дүн байхгүй.

САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

**“В” Засгийн газрын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс**

**Гадаад тусламжийн ангиуд (2.1.66, 2.1.70-р параграф)**

Тусламжийг дараах зориулалтаар ашиглана гэдгийг тусгайлан заасан хэлэлцээрийн дагуу тайлант үед олон талт болон хоёр талт гадаад тусламжийн агентлагуудаас гадаад тусламжийг хүлээн авсан:

	Хөгжлийн тусламж		Яаралтай тусламж		Бусад		Бүгд	
	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1
Зээлийн сан	X	X	-	-	X	-	X	X
Буцалтгүй тусламжийн сан	X	-	X	X	-	-	X	X
Нийт дүн	X	X	X	X	X	-	X	X
Ашигласан дүн	X	X	X	X	X	-	X	X

	Агентлаг 1		Агентлаг 2		Агентлаг 3		Агентлаг 4	
	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1
Зээлийн сан	X	X	-	-	X	-	X	X
Буцалтгүй тусламжийн сан	X	-	X	X	-	X	X	X
Нийт дүн	X	X	X	X	X	X	X	X
Валют:	X	X	-	-	-	-	-	-
Ам доллар	-	-	X	X	-	-	-	-
Евро	-	-	-	-	X	X	-	-
Иен	-	-	-	-	-	-	-	-
Бусад	-	-	-	-	-	-	X	X

**Зарцуулаагүй гадаад тусламж (2.1.72-р параграф)**

Зарцуулаагүй гадаад тусламжийн зээл, буцалтгүй тусламж нь гадаад тусламжийн агентлагуудтай байгуулсан заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заасан дүнгүүдээс бүрддэг боловч тайлангийн өдрөөр ашиглаагүй байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд биелүүлсэн болон ирээдүйд ханган биелүүлэхээр урьдчилан таамаглаж буй нөхцөл, болзолд захирагддаг. Хүчингүй болгосон буюу хугацаа дууссан гадаад тусламжийн зээл нь хөгжлийн төслүүдийн өртгийг илүү тооцсноос шалтгаалсан. Зарцуулаагүй тусламжийн зээл ба буцалтгүй тусламжийн дүнгийн өөрчлөлтийг уг байгууллагын толилуулгын валютаар толилуулсан.

	Хөгжлийн тусламж		Яаралтай тусламж		Бусад		Бүгд	
	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1
Эхний үлдэгдэл								
Зээл	X	X	-	-	X	X	X	X
Буцалтгүй тусламж	X	X	-	X	-	-	X	X
<b>Тайлант үед батлагдсан</b>								
Зээл	X	X	-	-	X	-	X	X
Буцалтгүй тусламж	X	X	X	X	X	X	X	X
<b>Ашиглах боломжтой нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
Ашигласан зээл	(X)	(X)	-	-	(X)	(X)	(X)	-
Ашигласан буцалтгүй тусламж	(X)	(X)	(X)	(X)	-	-	(X)	(X)
Хүчингүй болгосон/хугацаа дууссан зээл	(X)	(X)	-	-	-	-	(X)	(X)
Хүчингүй болгосон/хугацаа дууссан буцалтгүй тусламж	-	-	-	-	-	-	-	-
Ханшийн зөрүү	X	X	-	-	X	X	X	X
Эцсийн үлдэгдэл-Зээл	X	X	-	-	X	X	X	X
Эцсийн үлдэгдэл-Буцалтгүй тусламж	X	X	-	-	X	X	X	X

САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

Эцсийн үлдэгдэл-Эзэмшиж буй валютаар	Хөгжлийн тусламж		Яаралтай тусламж		Бусад		Бүгд	
	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1
Ам доллар	X	X	-	X	X	X	X	X
Евро	X	X	-	X	X	X	X	X
Иен	X	X	-	-	X	X	X	X
Бусад	X	X	-	-	-	-	X	-
<b>Толилуулгын валютаар</b>								
<i>Зээл</i>								
Агентлаг 1	X	X	-	-	X	X	X	X
Агентлаг 4	X	X	-	-	X	X	X	X
<i>Буцалтагүй тусламж</i>								
Агентлаг 2	X	X	-	X	X	X	X	X
Агентлаг 4	X	X	-	X	X	X	X	X
<b>Нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>-</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

**Гол чухал нөхцөл, болзол (2.1.76-р параграф)**

*Ерөнхий хязгаарлалтууд*

Гадаад тусламжийн амлалтын үлдэгдэл ба зарцуулаагүй үлдэгдэл нь тохиролцсон үйл ажиллагааны гүйцэтгэл, эсвэл эдийн засгийн болон санхүүгийн гүйцэтгэлийн тохиролцсон түвшний хадгалалтаар хязгаарлагддаг буюу захирагддаг.

Засгийн газар нь хөгжлийн тусламжийн орлогын хувьд эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө бэлтгэн гаргасан. Энэхүү төлөвлөгөө нь донор байгууллагуудын дэмжсэн ядуурлыг бууруулах стратегийг тусгасан байдаг. Засгийн газар болон донор байгууллагууд нь ядуурлыг бууруулах стратегийн хүрээнд дараах гол зорилтуудыг харилцан тохиролцсон: (Гол зорилтуудыг тодорхойлох байгууллага).

Засгийн газар болон донор байгууллагууд нь уг тохиролцсон зорилтуудад хүрэхийн тулд явцыг хянан үнэлэх арга зүйгээ харилцан зөвшөөрсөн бөгөөд явцыг хянах үүднээс жил бүр хуралдах юм.

Тусгай төслүүдийг дэмжих зээл ба буцалтгүй тусламж нь үйлчилгээ үзүүлэх өртөг зардлыг нөхөх зохих орлого бүрдүүлэх, одоо байгаа ашиглалтын хөрөнгүүдийг хэвийн ажиллуулах, хөрөнгийн сольж орлуулалт ба шинэчлэлийн хөтөлбөрт хувь нэмрээ оруулахын тулд бүх цахилгаан болон усан хангамжид зориулсан санхүүгийн гүйцэтгэлийн зорилтуудыг агуулсан байдаг.

*Худалдан авалтын хязгаарлалтууд*

Хүлээн авсан зарим хөгжлийн тусламж нь худалдан авах бараа, үйлчилгээний шинж төрөл, эсвэл бараа, үйлчилгээг худалдан авч болох улс орны хувьд хязгаарлалтанд захирагддаг. Олон талт хөгжлийн банкны бүх зээл буюу буцалтгүй тусламжийн хувьд дараах хязгаарлалтуудтай байдаг: (а) тэдний мөнгө санг цэргийн бараа, үйлчилгээ, тансаг хэрэгцээний бараа, байгаль орчинд хортой бараа худалдан авахад ашиглахыг хориглодог; ба (б) бараа, үйлчилгээг тэдгээрийн холбогдох гишүүн орнуудаас худалдан авах ёстой. Хоёр талт хамтын ажиллагааны агентлагуудаас авсан гадаад тусламж нь уг мөнгө санг олгож буй улсаас бараа, үйлчилгээг худалдан авах хязгаарлалттай эсвэл ийм хязгаарлалтгүй байдаг. Бүх “Тусгай Зориулалтын Зээл буюу Буцалтгүй тусламж” нь тусгайлан тодорхойлсон төслүүдийг санхүүжүүлдэг бөгөөд иймээс бараа, үйлчилгээний худалдан авалт нь төсөл тус бүрийн хувьд тохиролцсон орцоор хязгаарлагддаг.

**Бусад гол чухал нөхцөл, болзлын үл биелүүлэлт (2.1.83-р параграф)**

Газар хөдлөлтөөс шалтгаалсан барилгын ажлын саатлын улмаас боловсролын салбар дахь засгийн газрын зарлага нь зорилтот түвшинд хүрээгүй. Зарлага нь зорилтот түвшнээс Х хувиар бага байсан. Боловсролын салбар дахь дутуу хөрөнгө оруулалтыг засварлах арга хэмжээ авсан бөгөөд Засгийн газар ба холбогдох донор байгууллагууд нь уг төлөвлөсөн засварлах арга хэмжээг дэмжсэн. Засгийн газар нь хэрэгжиж буй бүх гадаад тусламжийн зээл ба буцалтгүй тусламжид хамаарах худалдан авалтын аливаа зохицуулалтыг даган мөрдсөн.

**Гадаад тусламжийн зээл ба буцалтгүй тусламжийн баталгаа (2.1.80-р параграф)**

“ҮҮҮҮ” засгийн газар нь ХХХ (200Х–1 онд тэг) мөнгөн дүн бүхий экспортын санхүүжилтийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд баталгаа гаргасан. Зээлийн үндсэн дүнг 5 жилийн дараа буцаан төлнө. Төлөгдөөгүй үлдэгдлээс тооцох хүүний түвшин нь Y хувь байна. Зөвхөн хүү болох үйлчилгээний төлбөрийг жил бүр төлдөг. Уг баталгаатай холбоотой өөр нэмэлт нөхцөл, болзол байхгүй. Гадаад тусламжийн бусад зээл буюу буцалтгүй тусламжийн хувьд гуравдагч талаас баталгаа гаргаагүй болно.

**Буцаан төлөх нөхцөл, болзол-Өр барагдуулах үүрэг (2.1.86-р параграф)**

Хөгжлийн тусламжийн зээлийн нөхцөлд 0 (тэг)-ээс хамгийн ихдээ 7 жил хүртэл төлбөр хойшлуулах хугацааг тусгасан байдаг. Хүү нь тогтмол ба хувьсах хүүний түвшний аль алиныг агуулдаг. Хөгжлийн тусламжийн бүх зээлийг ам доллар эсвэл еврогоор илэрхийлдэг. 200Х оны төсвийн жилийн хувьд тогтмол хүүтэй зээлийн хүү нь Х хувиас Y хувийн хооронд буюу жинэлсэн дундаж нь Z хувь байсан. 200Х–1 оны төсвийн жилийн хувьд хүү нь Х хувиас Y хувийн хооронд буюу жинэлсэн дундаж нь Z хувь байсан. Хувьсах хүүтэй зээлийн хүү нь ЛАЙБОР+Х хувиас ЛАЙБОР+Y хувийн хооронд буюу жинэлсэн дундаж нь 200Х оны төсвийн жилийн хувьд Z хувь, 200Х–1 оны төсвийн жилийн хувьд Z хувь байсан.

Бусад гадаад тусламжийн зээл нь төлбөр хойшлуулах хугацаагүй бөгөөд ам доллар, евро, иен гэх мэт янз бүрийн валютаар илэрхийлэгддэг.

	200Х он			
	Төлбөр хойшлуулах үлдсэн хугацааг жилээр харуулсан төлөгдөөгүй өр			
	Хугацаа дууссан	0-4	5-7	Бүгд
Хөгжлийн тусламж	X	X	X	X
Бусад	X	-	-	X
<b>Нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

	200Х-1 он			
	Төлбөр хойшлуулах үлдсэн хугацааг жилээр харуулсан төлөгдөөгүй өр			
	Хугацаа дууссан	0-4	5-7	Бүгд
Хөгжлийн тусламж	X	X	X	X
Бусад	X	-	-	X
<b>Нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

Хөгжлийн тусламжийн зээлүүд нь төлбөр хойшлуулах хугацаанаас хойш Х жилээс Y жил хүртэлх буцаан төлөх хугацаатай бөгөөд төлөгдөөгүй өрийн хувьд уг төлбөр хойшлуулах хугацааг оруулсан жинэлсэн дундаж хугацаа нь Z жил байна. Бүх тохиолдолд өр барагдуулалт нь үндсэн дүнгийн тогтмол төлбөр дээр хуримтлагдсан хүүг нэмсэн дүн байдаг.

САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

Бусад гадаад тусламжийн зээлүүд нь X жилээс Y жил хүртэлх буцаан төлөх хугацаатай бөгөөд жинэлсэн дундаж хугацаа нь Z жил байна. Өр барагдуулалт нь үндсэн дүнгийн тогтмол төлбөр дээр хуримтлагдсан хүүг нэмсэн дүн байдаг.

<b>200X он</b>					
<b>Өр барагдуулалт, үүн дотроо хүүний төлбөр</b>					
	<b>Ам доллар</b>	<b>Евро</b>	<b>Иен</b>	<b>Бусад</b>	<b>Бүгд</b>
Хөгжлийн тусламж	X	X	X	X	X
Бусад	X	X	-	-	X
<b>Нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

<b>200X-1 он</b>					
<b>Өр барагдуулалт, үүн дотроо хүүний төлбөр</b>					
	<b>Ам доллар</b>	<b>Евро</b>	<b>Иен</b>	<b>Бусад</b>	<b>Бүгд</b>
Хөгжлийн тусламж	X	X	X	X	X
Бусад	X	X	-	-	X
<b>Нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

Дараагийн жилүүдийн өр барагдуулалтын бүх төлбөр нь үндсэн дүн ба хүүний нийлбэрээс бүрдэх тогтмол дүн бүхий төлбөрт үндэслэдэг. Хүүний төлбөр буюу үйлчилгээний хураамжийн бүрэлдэхүүн хэсэг нь тайлант жилийн эцэс дэх зээл тус бүрийн төлөгдөөгүй үндсэн дүнд, харин хувьсах хүүтэй зээлийн хувьд тухайн өдрөөрх давамгайлах хүүний түвшинд үндэслэдэг. Гадаад валютаар илэрхийлсэн өр барагдуулалтын төлбөрийг тухайн санхүүгийн тайлангийн эцсийн өдрөөрх хаалтын ханшаар үржүүлснээр тодорхойлдог.

<b>200X+1 он ба дараагийн X жилүүд</b>					
<b>Өр барагдуулалт, үүн дотроо хүүний төлбөр</b>					
	<b>Ам доллар</b>	<b>Евро</b>	<b>Иен</b>	<b>Бусад</b>	<b>Бүгд</b>
Хөгжлийн тусламж	X	X	X	X	X
Бусад	X	X	-	-	X
<b>Нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

**Бараа, үйлчилгээний хүлээн авалт (2.1.90 ба 1.10.21-р параграфууд)**

200X онд ZZZ бүсэд маш хүчтэй газар хөтлөлт болж, засгийн газрын өмч хөрөнгө болон хувийн өмч хөрөнгөд, түүнчлэн ард иргэдэд асар их хохирол учруулсан. Хэд хэдэн улсын олон талт ба хоёр талт тусламжийн агентлагууд нь бул чулуунд дарагдсан хүмүүсийг аврах, шилжүүлэн байршуулахад туслахын тулд хүн хүчний болон тонон төхөөрөмжийн хандив туслалцаа үзүүлсэн. Түүнчлэн, сэтгэл заслаар сурч дадлагжсан мэргэшсэн эмнэлгийн ажилтнуудын багийг эмнэлгийн тоног төхөөрөмжийн хамт тус бүсэд илгээсэн. Мөн түр хоргодох байр болон хоол хүнсээр хангасан. Хүлээн авсан бараа, үйлчилгээний үнэ цэнийг XX дотоодын валютын нэгж болсон гэж тооцоолсон. Яаралтай тусламжийн хувьд адилтгах бараа, үйлчилгээний дотоод үнэ бэлэн боломжтой байхгүй учраас хоёр талт агентлагуудын гаргасан өртгийн тооцоололд үндэслэн тэдгээрийн үнэ цэнийг тодорхойлсон.

## САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

Тайлант жилд тавин мянган тонн цагаан будааг хүнсний туслалцаа байдлаар хүлээн авсан. Дотоодын бөөний зах зээл дэх адилтгах будааны бөөний үнийг харгалзан үүнийг ХХ дотоод валютын нэгж гэж үнэлсэн.

Тухайн жилийн туршид хүлээн авсан бараа, үйлчилгээг Мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнаагүй бөгөөд Засгийн газрын (шууд буюу шууд бусаар) хүлээн авсан эсвэл төлсөн мөнгийг зөвхөн тусгасан. Мөнгөн бус бараа, үйлчилгээг яаралтай тусламжийн нэг хэсэг байдлаар хүлээн авсан бөгөөд энэхүү тэмдэглэлд тусгасан.



## Хавсралт 3

### **УСНББОУС 2, Мөнгөн Гүйлгээний Тайлан-гаар шаардсан загвараар бэлтгэсэн Мөнгөн орлого, зарлагын тайлангийн толилуулга**

*Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт шилжихээр төлөвлөж буй байгууллага нь мөнгөн орлого, зарлагын тайлангаа УСНББОУС 2, “Мөнгөн Гүйлгээний Тайлан”-гаар шаардсантай ижил загвараар толилуулахыг энэ Стандартын Хоёрдугаар хэсгийн 2.2.1-р параграфтаар сайшаан дэмжсэн. Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар тайлагнаж буй байгууллага нь УСНББОУС 2-ыг мөрдөнө.*

*УСНББОУС 2-ын гол төлөв хандлагуудын тойм болон энэ Стандартаар шаардсан нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуух санхүүгийн тайлагналд түүнийг мөрдөх талаархи заавар удирдамжийг энэхүү Хавсралтад тусгасан. Мөнгөн орлого, зарлагын тайлангаа тохиромжтой тохиолдолд УСНББОУС 2-ын шаардлагуудын дагуу толилуулах санаа зорилго бүхий байгууллагууд нь уг УСНББОУС-ыг лавлагаа болгон харгалзах шаардлагатай.*

### **УСНББОУС 2, “Мөнгөн Гүйлгээний Тайлан”-гаар шаардсан загвараар толилуулах**

1. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь тайлант үеийн мөнгөн гүйлгээг доор тодорхойлсончлон, үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны гэж ангилан тайлагнах мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэхийг УСНББОУС 2-оор шаарддаг.

#### **Тодорхойлолтууд**

2. Санхүүгийн үйл ажиллагаа нь байгууллагын хувь нийлүүлсэн капитал ба зээлийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах үр дүн бүхий үйл ажиллагаа юм.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь мөнгөтэй адилтгах хөрөнгөнд хамаарахгүй урт хугацаат хөрөнгө ба бусад хөрөнгө оруулалтыг худалдан авах болон данснаас хасах үйл ажиллагаа юм.

Үндсэн үйл ажиллагаа нь байгууллагын хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа юм.

#### **Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд**

3. Мөнгөн орлого, зарлагын тайлангаа энэхүү загвараар толилуулахдаа, нэг ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн гүйлгээг өөр өөр арга замаар ангилах шаардлагатай байж болно (УСНББОУС 2-оор шаардсантай ижил загвараар толилуулах мөнгөн орлого, зарлагын тайлангийн хувьд энэ

## САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

Хавсралтын үлдсэн хэсэгт “мөнгөн гүйлгээний тайлан” гэсэн нэр томъёог ашигласан). Жишээлбэл; зээлийг буцаан төлөх мөнгө нь хүү ба үндсэн төлбөрийн аль алиныг агуулах тохиолдолд төлбөрийн хүүний хэсгийг үндсэн үйл ажиллагааны, зээлийн үндсэн төлбөрийг санхүүгийн үйл ажиллагааны гэж ангилж болох юм. Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх замаар өөрийн мэдээллийг толилуулж буй байгууллага нь үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээг өөрийн үйл ажиллагаанд хамгийн тохиромжтой арга маягаар толилуулна.

4. Мөнгөн гүйлгээний тайлан нь дараах дүнгүүдийг толилуулах мөрийн зүйлсийг агуулсан байна:

- (а) Үндсэн үйл ажиллагааны нийт мөнгөн орлого;
- (б) Үндсэн үйл ажиллагааны нийт мөнгөн зарлага;
- (в) Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ;
- (г) Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ;
- (д) Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ;
- (е) Мөнгөний эхний ба эцсийн үлдэгдэл; ба
- (ж) Мөнгөний цэвэр өсөлт эсвэл бууралт.

Нэмэлт мөрийн зүйлс, гарчиг, дэд дүнгүүдийн толилуулга нь тухайн байгууллагын мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулахад шаардлагатай тохиолдолд тэдгээрийг мөнгөн гүйлгээний тайланд бас толилуулна.

5. Байгууллага нь мөнгөн гүйлгээний тайланд эсвэл тэмдэглэлд дараах зүйлсийг мөн толилуулна:

- (а) Цэвэр дүнгээр тайлагнахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.13-р параграфтаар зөвшөөрснөөс бусад тохиолдолд үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн нийт мөнгөн орлого ба нийт мөнгөн зарлагын гол ангиуд;
- (б) Тухайн байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой арга маягаар харуулсан үндсэн үйл ажиллагааны нийт мөнгөн орлогын дэд ангилал; ба
- (в) Зарлагын шинж төрөл эсвэл тухайн байгууллагын хүрээн дэх чиг үүргийн аль тохиромжтойд үндэслэсэн ангилал ашиглан хийсэн үндсэн үйл ажиллагааны зарлагын задаргаа шинжилгээ.

Капитал худалдан авалт болон хүү, ногдол ашгийн хувьд хийсэн төлбөрийн тусдаа тодруулга нь УСНББОУС 2-ын шаардлагуудтай мөн нийцсэн байна.

6. Мөнгийг татвар, хураамж, торгууль (үндсэн үйл ажиллагаа), капитал хөрөнгийн борлуулалт (хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа) ба/буюу зээлээс (санхүүгийн үйл ажиллагаа) үүсгэн бий болгосон эсэх, түүнийг үйл

## САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

ажиллагааны зардал, капитал хөрөнгийн худалдан авалт (хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа) эсвэл өр барагдуулалтад (санхүүгийн үйл ажиллагаа) зарцуулсан эсэх гэх мэт асуудлуудын талаархи мэдээллийн тодруулга нь санхүүгийн тайлангийн ил тод ба хариуцлагатай байдлыг сайжруулдаг. Эдгээр тодруулга нь мөн тухайн байгууллагын одоогийн мөнгөний нөөц, ирээдүйн мөнгөн орлогын магадлалт эх үүсвэр болон тогтвортой байдлын талаар илүү их мэдээлэл бүхий шинжилгээ, үнэлгээнд туслалцаа үзүүлдэг. Иймээс бүх байгууллагууд нь энэхүү мэдээллийг санхүүгийн тайлан ба/буюу холбогдох тэмдэглэлд тодруулахыг энэхүү Стандартаар сайшаан дэмждэг.

### Үндсэн үйл ажиллагаа

7. Үндсэн үйл ажиллагаанаас үүсэх цэвэр мөнгөн гүйлгээний дүн нь тухайн байгууллагын үйл ажиллагааг дараах байдлаар санхүүжүүлсэн хэмжээг илэрхийлэх гол үзүүлэлт юм:

- (a) (Шууд ба шууд бус) татвараар; эсвэл
- (b) Тухайн байгууллагын нийлүүлсэн бараа, үйлчилгээг хүлээн авагчдаар.

Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүнгийн тодруулга нь зээлийг буцаан төлөх, өөрийн эздэд ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг төлөх, санхүүжилтийн гадаад эх үүсвэрээс мөнгө авахгүйгээр шинэ хөрөнгө оруулалтуудыг хийхэд ашиглах мөнгө бий болгох тухайн байгууллагын үйл ажиллагааны хүчин чадлыг тодорхойлоход мөн туслалцаа үзүүлдэг. Нийт засгийн газрын түвшний нэгтгэсэн, үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь өөрийн одоогийн үйл ажиллагааг уг Засгийн газар татвар болон төлбөрөөр санхүүжүүлсэн хэмжээг илэрхийлэх үзүүлэлтээр хангадаг. Үндсэн үйл ажиллагааны урьд өмнөх түүхэн мөнгөн гүйлгээний тодорхой бүрдэл хэсгүүдийн талаархи мэдээлэл нь бусад мэдээллийн хамтаар уг үндсэн үйл ажиллагааны ирээдүйн мөнгөн гүйлгээг прогнозчилоход ач холбогдолтой байдаг.

8. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагын мөнгө бий болгох үндсэн үйл ажиллагаанаас юуны өмнө үүсдэг. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний жишээг доор дурдав:

- (a) Татвар, хураамж, торгуулиас бий болсон мөнгөн орлого;
- (b) Тухайн байгууллагын нийлүүлсэн бараа, үйлчилгээний төлбөрөөс орсон мөнгөн орлого;
- (b) Буцалтгүй тусламж буюу шилжүүлэг ба төв засгийн газар эсвэл улсын секторын бусад байгууллагуудаас олгосон, үүн дотроо капитал хөрөнгийн худалдан авалтын хувьд олгосон бусад хуваарилалт болон төсвийн бусад эрх мэдлээс үүссэн мөнгөн орлого;
- (г) Эрхийн шимтгэл, төлбөр, хураамж ба бусад орлогоос бий болсон мөнгөн орлого;

## САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

- (д) Улсын секторын бусад байгууллагуудад тэдгээрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан олгосон мөнгөн төлбөр (үүнд: зээл болон өмчийн санхүүжилт хамаарахгүй);
  - (е) Бараа, үйлчилгээний хувьд бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгөн төлбөр;
  - (ж) Ажиллагчдад төлсөн эсвэл тэдний өмнөөс төлсөн мөнгөн төлбөр;
  - (и) Улсын секторын даатгалын байгууллагын даатгалын хураамж, хохирлын төлбөр, аннуити болон даатгалын гэрээний бусад үр өгөөжийн мөнгөн орлого ба мөнгөн төлбөр;
  - (к) Үндсэн үйл ажиллагаанд хамаарах үл хөдлөх хөрөнгийн орон нутгийн татвар эсвэл орлогын албан татварын (хамааралтай бол) мөнгөн төлбөр;
  - (л) Худалдаа буюу арилжааны зорилготой гэрээнээс үүссэн мөнгөн орлого ба мөнгөн төлбөр;
  - (м) Зогсоосон үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн орлого буюу мөнгөн төлбөр; ба
  - (н) Зарга, маргааны барагдуулалттай холбоотой мөнгөн орлого буюу мөнгөн төлбөр;
9. Байгууллага нь үнэт цаас болон зээлийг арилжаа буюу худалдааны зорилгоор эзэмшиж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээр нь буцаан борлуулах зорилгоор тусгайлан худалдан авсан бараа материалтай ижил байдаг. Иймээс арилжаа буюу худалдааны зорилготой үнэт цааснуудын худалдан авалт, борлуулалтаас үүссэн мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилдаг. Үүнтэй адилаар, улсын санхүүгийн байгууллагаас олгосон мөнгөн урьдчилгаа ба зээл нь тухайн байгууллагын мөнгө бий болгох гол үйл ажиллагаатай холбоотой учраас тэдгээрийг ихэвчлэн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилдаг.
10. Зарим улс оронд, засгийн газар буюу улсын секторын бусад байгууллагууд нь тухайн байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд төсөв хуваарилах буюу мөнгө сангийн эрх олгодог боловч тэдгээр мөнгө санг урсгал үйл ажиллагаанд, капитал ажилд болон хувь нийлүүлсэн капиталд хуваарилан зарцуулах талаар тодорхой ялган заагаагүй байдаг. Байгууллага нь төсвийн хуваарилалт буюу төсвийн эрхийг урсгал үйл ажиллагаа, капитал ажил (үндсэн үйл ажиллагаа), хувь нийлүүлсэн капитал (хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа) гэдгээр тус тусад нь ялган тодорхойлох боломжгүй тохиолдолд уг төсвийн хуваарилалт буюу төсвийн эрхийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байдлаар ангилж бөгөөд санхүүгийн тайлангийн тэмдэглэлд энэ тухай тодруулга хийх хэрэгтэй гэж УСНББОУС 2-т тайлбарласан байдаг.

### **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа**

11. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээний тусдаа тодруулга нь тухайн байгууллагын ирээдүйн үйлчилгээ үзүүлэлтэнд хувь

## САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

нэмрээ оруулах зориулалт бүхий нөөцийн хувьд зарцуулсан мөнгөн зарлагын гүйлгээний дүнг илэрхийлдэг. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээний жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгийг худалдан авахад төлсөн мөнгө. Капиталжуулсан хөгжүүлэлтийн зардал болон өөрөө барьж байгуулсан үндсэн хөрөнгөтэй холбоотой төлбөрүүд нь энэхүү дүнд хамаарна;
- (б) Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгийг борлуулсны мөнгөн орлого;
- (в) Бусад байгууллагуудын өмчийн буюу өрийн хэрэглүүр болон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог худалдан авахад төлсөн мөнгөн төлбөр (мөнгөтэй адилтгах хөрөнгө гэж үзэх хэрэглүүр эсвэл худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж буй хэрэглүүрийн хувьд төлснөөс бусад мөнгөн төлбөр);
- (г) Бусад байгууллагуудын өмчийн буюу өрийн хэрэглүүр болон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны борлуулалтаас үүссэн мөнгөн орлого (мөнгөтэй адилтгах хөрөнгө гэж үзэх хэрэглүүр болон худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж буй хэрэглүүрээс үүссэнээс бусад мөнгөн орлого);
- (д) Бусад талуудад олгосон зээл ба мөнгөн урьдчилгаа (улсын санхүүгийн байгууллагаас олгосон зээл ба мөнгөн урьдчилгаанаас бусад);
- (е) Бусад талуудад олгосон зээл ба мөнгөн урьдчилгааны буцаан төлөлтөөс хүлээн авсан мөнгө орлого (улсын санхүүгийн байгууллагын зээл ба мөнгөн урьдчилгаанаас бусад);
- (ж) Худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж байгаа гэрээ эсвэл мөнгөн төлбөрүүдийг нь санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилснаас бусад тохиолдолд фьючерс гэрээ, форвард гэрээ, опционы гэрээ, свопын гэрээний хувьд төлсөн мөнгө төлбөр; ба
- (и) Худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж байгаа гэрээ эсвэл мөнгөн орлогуудыг нь санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилснаас бусад тохиолдолд фьючерс гэрээ, форвард гэрээ, опционы гэрээ, свопын гэрээнээс үүссэн мөнгө орлого.

Гэрээг тодорхойлж болох төлөв байдлын хейж гэж тайлагнасан тохиолдолд уг гэрээний мөнгөн гүйлгээг тухайн хейж хийж буй төлөв байдлын мөнгөн гүйлгээтэй ижил арга замаар ангилна.

### **Санхүүгийн үйл ажиллагаа**

12. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тусдаа тодруулга нь тухайн байгууллагад капитал нийлүүлэгчдийн зүгээс ирээдүйн мөнгөн гүйлгээнд тавих шаардлагыг урьдчилан таамаглахад ач холбогдолтой байдаг. Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээний жишээнд дараах зүйлс хамаарна:

## САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

- (а) Баталгаагүй өрийн бичиг, зээл, баталгаат өрийн бичиг, бонд, моргейжийн (үл хөдлөх хөрөнгийн барьцаат) болон бусад богино буюу урт хугацаат зээллэгийн хэрэглүүр гаргалтаас хүлээн авсан мөнгөн орлого;
- (б) Зээлийг буцаан төлөх мөнгөн төлбөр;
- (в) Санхүүгийн түрээстэй холбоотой төлөгдөөгүй өр төлбөрийн бууралт болгон түрээслэгчийн төлсөн мөнгөн төлбөр.
- (г) Валютын гаргалт эсвэл эргэлтээс гаргалттай холбоотой мөнгөн орлого, зарлага.

### **Хүү ба ногдол ашиг**

- 13. Хүлээн авсан ба төлсөн хүү, ногдол ашгаас үүссэн мөнгөн гүйлгээний тусдаа тодруулга хийхийг УСНББОУС 2-оор шаардсан байдаг. Ийм тодруулга хийдэг тохиолдолд тэдгээр мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны гэдгээр нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай ангилах хэрэгтэй гэж УСНББОУС 2-д бас заасан.
- 14. Тайлант үеийн туршид төлсөн ба хүлээн авсан хүү, ногдол ашгийн нийт дүнг мөнгөн гүйлгээний тайланд толилуулна. Төлсөн хүү ба хүлээн авсан хүү, ногдол ашгийг улсын санхүүгийн байгууллагын хувьд ихэвчлэн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилдаг. Харин бусад байгууллагуудын хувьд төлсөн ба хүлээн авсан хүү, ногдол ашигтай холбоотой мөнгөн гүйлгээг хэрхэн ангилах талаар зөвшилцөлд хүрээгүй байна. Төлсөн хүү ба ногдол ашиг, хүлээн авсан хүү ба ногдол ашгийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилж болох юм. Гэвч нөгөө талаас, төлсөн хүү ба ногдол ашиг, хүлээн авсан хүү ба ногдол ашиг нь санхүүгийн эх үүсвэр олж авах өртөг зардал буюу хөрөнгө оруулалтын өгөөж тул тэдгээрийг харгалзан санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилж болох юм.

### **Орлого, зарлагын гол ангиудын тайлагнал**

- 15. Орлогын дэд ангилал нь тухайн хамаарах дүнгийн хэмжээ, шинж төрөл, чиг үүргээс хамаардаг. Байгууллагын онцлогоос хамааран дараах дэд ангиллууд тохиромжтой байж болно:
  - (а) Татварын орлого (татварын төрлүүдээр цаашид дэд ангилж болно);
  - (б) Хураамж, торгууль, алданги болон зөвшөөрлийн орлого;
  - (в) Арилжааны ажил гүйлгээний орлого, үүн дотроо бараа, үйлчилгээний борлуулалт ба хэрэглэгчдийн төлбөр (эдгээрийг арилжааны ажил гүйлгээ гэж ангилдаг тохиолдолд);
  - (г) Буцалтгүй тусламж, шилжүүлэг буюу төсвийн хуваарилалтын орлого (эх үүсвэрээр ангилж болно); ба

## САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

(д) Хүү болон ногдол ашгийн орлого.

16. Тухайн тайлагнагч байгууллагын тодорхой хөтөлбөр, үйл ажиллагаа буюу бусад холбогдох сегментүүдийн өртөг зардал болон өртгийн нөхөлтийг онцлон илэрхийлэхийн тулд зарлагын зүйлсийг дэд ангиллаар харуулдаг. Зарлагын шинж төрөл болон чиг үүргээр хийсэн ангиллын жишээг энэ Стандартын Нэгдүгээр хэсэгт тусган харуулсан.

## Хавсралт 4

### Санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд

*Санхүүгийн тайлан нь олон тооны чанарын шинжүүдийг хангасан мэдээллэл толилуулахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.32-р параграфтаар шаардсан байдаг. Санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг энэ Хавсралтад хураангуйлан харуулав.*

Чанарын шинжүүд нь санхүүгийн тайлангаар хангах мэдээллийг хэрэглэгчдэд ач холбогдолтой болгодог шинжүүд юм. Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн сууриас үл хамааран чанарын шинжүүдийг санхүүгийн тайланд хэрэглэдэг. Чанарын үндсэн дөрвөн шинж нь ойлгомжтой байх, хамааралтай байх, найдвартай байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх гэсэн шинжүүд юм.

#### **Ойлгомжтой байх**

Хэрэглэгчид түүний утгыг ойлгоно гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох тохиолдолд мэдээлэл нь ойлгомжтой байдаг. Энэ зорилгын хувьд хэрэглэгчид нь байгууллагын үйл ажиллагаа болон түүний үйл ажиллагаа явуулдаг орчны талаар зохих мэдлэгтэй, тухайн мэдээллийг судлахад бэлэн байдаг гэж төсөөлнө.

Нарийн цогц асуудлуудын талаархи мэдээллийг зарим хэрэглэгчдийн хувьд ойлгоход хэт төвөгтэй байж болно гэсэн ганц үндэслэлээр санхүүгийн тайланд тусгахгүй орхиж болохгүй юм.

#### **Хамааралтай байх**

Өнгөрсөн, одоо, ирээдүйн үйл явдлуудыг үнэлэх, эсвэл өмнөх үнэлгээг баталгаажуулах буюу засварлахад туслалцаа үзүүлэхийн тулд түүнийг ашиглаж болохоор байвал мэдээлэл нь хэрэглэгчдэд хамааралтай байдаг. Хамааралтай байхын тулд мэдээлэл нь мөн цаг хугацаандаа байх ёстой.

#### *Материаллаг байдал*

Мэдээллийн хамааралтай байдалд түүний шинж төрөл ба материаллаг байдал нөлөө үзүүлдэг.

Мэдээллийн орхигдуулалт буюу буруу илэрхийлэлт нь уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн шийдвэр буюу хяналт үнэлгээнд нөлөө үзүүлж чадахаар байвал түүнийг материаллаг гэж үзнэ. Материаллаг байдал нь тухайн нөхцөл байдлын хүрээнд шүүн тунгаах уг орхигдуулалт буюу буруу илэрхийлэлтийн шинж төрөл ба хэмжээнээс хамаардаг. Иймээс материаллаг байдал нь тухайн мэдээлэл ач холбогдолтой байхын тулд агуулах ёстой чанарын үндсэн шинж чанар биш, харин босго шалгуур буюу тасалбар болгох цэгийг тогтоодог.



## **Найдвартай байх**

Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм.

### *Үнэн зөв илэрхийлэх*

Ажил гүйлгээ ба бусад үйл явдлыг үнэн зөв илэрхийлэх мэдээллийн хувьд тухайн ажил гүйлгээ, бусад үйл явдлын зөвхөн хуулийн хэлбэр биш, харин мөн чанарын дагуу түүнийг толилуулах хэрэгтэй.

### *Хэлбэрээс илүү мөн чанар*

Хэрэв мэдээлэл нь өөрийн илэрхийлэхийг зорьж буй ажил гүйлгээ ба бусад үйл явдлыг үнэн зөв илэрхийлдэг бол тэдгээрийг зөвхөн хуулийн хэлбэр биш, харин мөн чанар ба эдийн засгийн бодит байдлын дагуу тайлагнаж, толилуулах шаардлагатай юм. Ажил гүйлгээ буюу бусад үйл явдлын мөн чанар нь тэдгээрийн хуулийн хэлбэртэй үргэлж нийцээд байдаггүй.

### *Төв голч байх*

Мэдээлэл нь аль нэг талыг барьж, туйлшраагүй бол төв голч байдаг. Урьдчилан тодорхойлсон үр дүн буюу үр дагаварт хүрэх үүднээс шийдвэр гаргалт болон шүүн тунгаалтанд нөлөөлөхийн тулд зохиомжилсон тийм арга маягаар санхүүгийн тайланд агуулагдаж буй мэдээллийг сонгосон буюу толилуулсан бол тухайн санхүүгийн тайлан нь төв голч бус болно.

### *Хянамгай байх*

Хянамгай байдал нь тодорхойгүй нөхцөл байдалд шаардлагатай тооцооллын хувьд, хөрөнгө ба орлогыг илүү илэрхийлээгүй, өр төлбөр ба зардлыг дутуу илэрхийлээгүй гэх мэтээр шүүн тунгаалт хийхдээ анхаарал болгоомжтой хандах хэм хэмжээ юм.

### *Иж бүрэн байх*

Санхүүгийн тайлан дахь мэдээлэл нь материаллаг байдал ба өртөг зардлын хязгаарын хүрээнд иж бүрэн байвал зохино.

## **Зэрэгцүүлэгдэх боломжтой байх**

Санхүүгийн тайлан дахь тухайн мэдээлэл ба өөр бусад тайлан дахь мэдээллийн хоорондох ижил төсөөтэй болон ялгаатай талуудыг хэрэглэгч нар ялган тогтоох боломжтой тохиолдолд санхүүгийн тайлангийн мэдээлэл нь зэрэгцүүлэгдэх боломжтой байдаг.

Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь дараах зүйлсэд хамаарна:

- Өөр өөр байгууллагуудын санхүүгийн тайлангуудын зэрэгцүүлэлт; ба
- Нэг байгууллагын өөр өөр тайлант үеүдийн санхүүгийн тайлангуудын зэрэгцүүлэлт.

Зэрэгцүүлэгдэх боломжтой байх шинж чанарын гол утга санаа нь тухайн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан бодлогууд, тэдгээрийн өөрчлөлт, уг өөрчлөлтийн үр нөлөөний талаар хэрэглэгчдэд мэдээлэх явдал юм.

Хэрэглэгчид нь тухайн байгууллагын үр дүнг цаг хугацааны явцад зэрэгцүүлэхийг хүсдэг учраас өмнөх тайлант үеүдийн харгалзах мэдээллийг тухайн санхүүгийн тайланд харуулах нь ач холбогдолтой байдаг.

### **Хамааралтай ба найдвартай мэдээллийн хязгаарлалтууд**

#### *Цаг хугацаандаа байх*

Мэдээллийн тайлагналын хугацааг хэт хойшлуулвал түүний хамааралтай байдал алдагдаж болох юм. Мэдээллээр цаг хугацаанд нь хангахын тулд тухайн ажил гүйлгээний бүх төлөв байдал мэдэгдэхээс өмнө ихэвчлэн тайлагнах шаардлагатай байж болох бөгөөд ингэснээр найдвартай байдлыг багасгадаг. Харин эсрэгээр, бүх төлөв байдал мэдэгдэх хүртэл тайлагналыг хойшлуулвал уг мэдээлэл нь ихээхэн найдвартай байж болох боловч завсарын хугацаанд шийдвэр гаргах шаардлагатай хэрэглэгчдийн хувьд ач холбогдол багатай байдаг. Хамааралтай ба найдвартай байдлын хоорондох тэнцвэрт хүрэхийн тулд хамгийн гол анхаарах зүйл нь хэрэглэгчдийн шийдвэр гаргалтын хэрэгцээг хамгийн сайн хангах явдал юм.

#### *Өгөөж ба өртгийн хоорондох тэнцвэр*

Өгөөж ба өртгийн хоорондох тэнцвэр нь нийтлэг хязгаарлалт юм. Мэдээллээс хүртэх өгөөж нь түүнийг бэлтгэх өртгөөс илүү байвал зохино. Гэвч өгөөж ба өртгийн үнэлгээ нь ямагт шүүн тунгаалтын асуудал байдаг. Түүнчлэн, өртөг нь өгөөж хүртэж буй хэрэглэгчдэд ямагт хамаараад байдаггүй. Мөн тухайн мэдээллийг зориулан бэлтгэсэн хэрэглэгчдээс өөр бусад хэрэглэгч нар өгөөж хүртэж болох юм. Эдгээр шалтгааны улмаас аливаа тодорхой тохиолдолд өртөг-өгөөжийн сорилыг хэрэглэхэд төвөгтэй байдаг. Гэвч стандарт тогтоогчид, санхүүгийн тайлан бэлтгэх үүрэг бүхий этгээдүүд болон санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь энэ хязгаарлалтыг мэддэг байвал зохино.

#### *Чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр*

Практикт чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр буюу уялдааг ямагт тогтоох шаардлагатай байдаг. Ерөнхийдөө, зорилго нь санхүүгийн тайлангийн зорилтуудыг хангахын тулд чанарын шинжүүдийн хоорондох зохих тэнцвэрт хүрэх явдал юм. Өөр өөр нөхцөл байдал дахь чанарын шинжүүдийн харьцангуй ач холбогдол нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал байдаг.

## Хавсралт 5

### Санхүүгийн тайлагналын зорилгоор өөр байгууллагад хяналт тогтоох

1. Санхүүгийн тайлагналын зорилгоор өөр байгууллагыг тухайн байгууллага хянадаг эсэх нь энэ Стандартад заасан хяналтын тодорхойлолт болон тохиолдол тус бүрийн тухайн нөхцөл байдалд үндэслэсэн шүүн тунгаалтын асуудал юм. Өөрөөр хэлбэл, хоёр байгууллагын хоорондох харилцаа холбооны шинж төрөлд ач холбогдол өгөх шаардлагатай байдаг. Ялангуяа, энэ Стандартад заасан хяналтын тодорхойлолтын хоёр элементийг харгалзан үзэх шаардлагатай болдог. Бүрэн эрхийн элемент (өөр байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг удирдах бүрэн эрх) ба өгөөжийн элемент (өөр байгууллагын үйл ажиллагаанаас өгөөж хүртэх уг хяналт тавигч байгууллагын чадвар боломжийг илэрхийлэх) гэсэн хоёр элемент байдаг.
2. Хяналт тогтоохын зорилго нь нөгөө байгууллагын үйл ажиллагаанаас уг хяналт тавигч байгууллага өгөөж хүртэх явдал юм. Жишээлбэл; байгууллага нь ашгийн хуваарилалт хэлбэрээр (ногдол ашиг гэх мэт) нөгөө байгууллагын үйл ажиллагаанаас өгөөж хүртэж болох ба боломжит гарзын эрсдлийг хүлээдэг. Өөр зарим тохиолдолд байгууллага нь нөгөө байгууллагаас ямар нэг санхүүгийн өгөөж хүртдэггүй боловч өөрийн зорилтуудад хүрэхийн тулд уг нөгөө байгууллагыг удирдан чиглүүлэх чадвар боломжоос өгөөж хүртэж болох юм. Түүнчлэн, байгууллага нь нөгөө байгууллагын үйл ажиллагаанаас санхүүгийн болон санхүүгийн бус өгөөжийн аль алиныг хүртэх боломжтой байж болно. Жишээлбэл; Улсын Үйлдвэрийн Газар (УҮГ) нь хяналт тавигч байгууллагадаа ногдол ашиг олгодог ба түүний нийгмийн бодлогын зарим зорилтуудыг биелүүлэх боломж олгодог байж болох юм.

### Санхүүгийн тайлагналын зорилго бүхий хяналт

3. Санхүүгийн тайлагналын зорилгын хувьд хяналт нь нөгөө байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг удирдах уг байгууллагын бүрэн эрхээс үүсдэг бөгөөд тус байгууллага нь нөгөө байгууллагад хувьцааны буюу бусад өмчийн хувь оролцооны заавал олонхийн эзэмшилтэй байх шаардлагагүй юм. Хяналт тавих бүрэн эрх нь одоо хэрэгжих боломжтой байх ёстой. Өөрөөр хэлбэл, байгууллага нь хууль тогтоомж буюу албан ёсны хэлцлээр түүнд угаасаа олгосон бүрэн эрхтэй байх ёстой. Хяналт тавих бүрэн эрхийг хүчин төгөлдөр болгохын тулд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах эсвэл хэлцлийг дахин хэлэлцэн тохирох шаардлагатай бол уг бүрэн эрх одоогоор хэрэгжих боломжгүй байдаг. Иймээс нөгөө байгууллагад хяналт тавих бүрэн эрхийн оршин байдал нь уг бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломж буюу магадлалаас хамааралгүй гэдгийг ялган зааглах хэрэгтэй.
4. Үүнтэй адилаар, хяналтын оршин байдал нь нөгөө байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах (эсвэл оролцох) үүрэг хариуцлагатай

байхыг тухайн байгууллагаас шаардахгүй. Олон тохиолдолд байгууллага нь хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй байгууллагын хоорондох хэлцлийг зөвхөн зөрчих буюу хүчингүй болгосноор нөгөө байгууллагад хяналт тавих өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байж болно.

5. Жишээлбэл; засгийн газрын хэлтэс газар нь УҮГ байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг төмөр замын хэрэг эрхлэх газарт өмчлөлийн хувь оролцоотой байж болно. Төмөр замын хэрэг эрхлэх газар нь бие даасан байдлаар үйл ажиллагаагаа явуулах эрхтэй ба засгийн газраас санхүүжилт авдаггүй боловч засгийн газрын баталгаа гаргасан томоохон зээлээр дамжуулан хөрөнгө босгосон. Төмөр замын хэрэг эрхлэх газар нь нэлээд хэдэн жилийн хугацаанд засгийн газарт ногдол ашиг олгоогүй. Засгийн газар нь Төмөр замын хэрэг эрхлэх газрын удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийг томилох ба чөлөөлөх бүрэн эрхтэй. Засгийн газар нь удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх бүрэн эрхээ хэзээ ч хэрэгжүүлж байгаагүй бөгөөд төмөр замын сүлжээний үйл ажиллагаа дахь өмнөх засгийн газрын оролцооны хувьд сонгогчдын эмзэг мэдрэмжтэй байдлаас хамааран ингэж оролцох дургүй байдаг. Энэ тохиолдолд хяналт тавих бүрэн эрхийг одоо хэрэгжүүлэх боломжтой боловч хяналтанд буй байгууллага ба хяналт тавигч байгууллагын хоорондох одоогийн харилцааны дагуу хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд буй байгууллагад өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлнэ гэдгийг илэрхийлэх үйл явдал гарч тохиолдоогүй байна. Хэдийгээр хяналт тавигч байгууллага нь өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх сонголт хийгээгүй боловч хяналт тавих бүрэн эрх хангалттай байгаа тул хяналт оршин байна гэж үзнэ.
6. Хууль ёсны тусдаа бүрэн эрхийн оршин байдал нь тухайн байгууллагыг өөр байгууллага хянахад дангаараа саад учруулахгүй. Жишээлбэл; Засгийн газрын Статистикийн Алба нь засгийн газар буюу бусад аливаа этгээдээс хараат бусаар мэдээллийг олж авах, тайланг хэвлэн нийтлэх хууль ёсны бүрэн эрхтэй байж болно. Хяналтын оршин байдал нь нөгөө байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд эсвэл мэргэжлийн чиг үүргээ тэрхүү байгууллага гүйцэтгэх арга хэлбэрийн хувьд үүрэг хариуцлага хүлээхийг тухайн байгууллагаас шаардахгүй.
7. Нөгөө байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлоготой холбоотой шийдвэр гаргалтыг удирдах нэг байгууллагын бүрэн эрх нь энэ Стандартад тодорхойлсон хяналт оршин байдлыг хангахад дангаараа хангалтгүй байдаг. Хяналт тавигч байгууллага нь нөгөө байгууллагын үйл ажиллагаанаас өгөөж хүртэхийн тулд түүний шийдвэр гаргалтыг удирдах боломжтой, тухайлбал, өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ тус эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг хэсэг байдлаар түүнийг өөртэйгээ хамтран ажиллуулах боломжтой байх шаардлагатай. Энэ санаа нь цаашид үргэлжлэхгүй харилцааг, тухайлбал татан буулгагч ба татан буугдаж буй байгууллага хоорондын, зээлдэгч ба зээлдүүлэгч хоорондын харилцааг “хяналт тавигч байгууллага” ба “хяналтанд буй байгууллага” хоорондын харилцааны тодорхойлолтоос хасах үр нөлөөтэй байдаг. Үүнтэй адилаар, итгэлцлийн сантай холбогдох харилцаа нь итгэмжлэгдсэн этгээдийн хэвийн

үүрэг хариуцлагаас цааш үргэлжлэхгүй тийм итгэмжлэгдсэн этгээдийг энэ Стандартын зорилгын хувьд тэрхүү итгэлцлийн санг хянадаг гэж үзэхгүй.

### **Зохицуулалтын болон худалдан авалтын бүрэн эрх**

8. Засгийн газрууд болон засгийн газрын байгууллагууд нь өөрсдийн онцгой бүрэн эрх буюу хууль ёсны бүрэн эрхийг ашиглах замаар олон байгууллагуудын төлөв байдлыг зохицуулах бүрэн эрхтэй байдаг. Зохицуулалтын болон худалдан авалтын бүрэн эрх нь санхүүгийн тайлагналын зорилго бүхий хяналтыг бий болгохгүй. Улсын секторын байгууллагын хянаж, өгөөж хүртэж болох зөвхөн тэдгээр нөөцийг (мөнгө, үүн дотроо мөнгөтэй адилгах хөрөнгө) түүний санхүүгийн тайланд тусгасан гэдгийг ханган магадлахын тулд энэ Стандартын зорилгын хувьд хяналтын утга агуулгад дараах зүйлсийг хамруулдаггүй:
- (а) Байгууллагын үйл ажиллагаа явуулах зохицуулалтын хүрээ ба тэдний үйл ажиллагааны хувьд нөхцөл тогтоох буюу хариуцлага хүлээлгэх хууль тогтоомжийн бүрэн эрх. Ийм бүрэн эрх нь тэдгээр байгууллагуудын эзэмшиж ашиглаж буй хөрөнгөнд улсын секторын байгууллагын зүгээс тавих хяналтыг бий болгохгүй. Жишээлбэл; бохирдлыг хянах эрх бүхий байгууллага нь байгаль орчны дүрэм, журмыг даган мөрдөөгүй байгууллагуудын үйл ажиллагааг хаах бүрэн эрхтэй байж болно. Гэвч бохирдлыг хянах эрх бүхий байгууллага нь зөвхөн зохицуулах бүрэн эрхтэй учраас энэхүү бүрэн эрх нь хяналтыг бий болгохгүй юм.
  - (б) Улсын секторын байгууллагаас эдийн засгийн хувьд хараат байгууллагууд. Өөрөөр хэлбэл, байгууллага нь улсын секторын байгууллагаас санхүүжилт авах, эсвэл түүнтэй бизнес хийх эсэх сонголттой тохиолдолд тухайн байгууллага нь өөрийн санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг удирдах эцсийн бүрэн эрхтэй, иймээс түүнийг улсын секторын байгууллага хянадаггүй. Жишээлбэл; засгийн газрын хэлтэс газар нь санхүүжилтийн хувьд түүнээс хараат байгууллагын (буяны байгууллага гэх мэт) эсвэл бизнесийн хувьд түүнээс эдийн засгийн хараат ашгийн төлөө байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогод нөлөө үзүүлэх боломжтой байж болно. Ингэснээр тус засгийн газрын хэлтэс газар нь худалдан авагчийн хувьд зарим бүрэн эрхтэй боловч тус байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг удирдахгүй юм.

### **Санхүүгийн тайлагналын зорилгоор хяналт оршиж буй эсэхийг тодорхойлох**

9. Улсын секторын байгууллагууд нь өөрсдийн зарим зорилтыг биелүүлэхийн тулд бусад байгууллагуудыг үүсгэн байгуулж болно. Зарим тохиолдолд ийм байгууллагыг хянадаг, иймээс нэгтгэх хэрэгтэй гэдэг нь тодорхой байдаг. Гэвч өөр зарим тохиолдолд энэ нь тодорхой бус байж болно. Санхүүгийн тайлагналын зорилгоор хяналт оршин буй эсэхийг тодорхойлоход туслах заавар удирдамжийг доорх 10 ба 11-р параграфт тусгасан.

10. Хоёр байгууллагын хоорондох харилцааг авч үзэх үед, нөгөө байгууллага хянаж буй гэсэн тодорхой нотолгоо байхаас бусад тохиолдолд хамгийн наад зах нь, дараах бүрэн эрхийн нөхцлүүдийн аль нэг болон дараах өгөөжийн нөхцлүүдийн аль нэг биелж байвал хяналт оршин байна гэж урьдчилан төсөөлнө.

*Бүрэн эрхийн нөхцлүүд*

- (а) Байгууллага нь нөгөө байгууллагын саналын эрхийн олонхийг шууд эсвэл хяналтанд буй байгууллагуудаар дамжуулан шууд бусаар эзэмшдэг.
- (б) Байгууллага нь одоогийн хууль тогтоомжийн дагуу олгогдсон буюу хэрэгжүүлэх эрхийн дагуу нөгөө байгууллагын удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийг томилох буюу чөлөөлөх бүрэн эрхтэй байх.
- (в) Байгууллага нь нөгөө байгууллагын ерөнхий хурлаар бүрдэх магадлалтай олонхийн саналын эрхийг бүрдүүлэх эсвэл саналын эрхийн бүрдүүлэлтийг зохицуулах бүрэн эрхтэй байх.
- (г) Байгууллага нь захирлуудын зөвлөл буюу адилтгах удирдах байгууллагын хуралд саналын эрхийн олонхийг бүрдүүлэх бүрэн эрхтэй байх.

*Өгөөжийн нөхцлүүд*

- (а) Байгууллага нь нөгөө байгууллагыг татан буулгах ба үлдэх эдийн засгийн үр өгөөжийн мэдэгдэхүйц хэсгийг авах эсвэл мэдэгдэхүйц үүргийг хариуцах бүрэн эрхтэй байх. Жишээлбэл; хэрэв байгууллага нь нөгөө байгууллагын үлдэх өр төлбөрийг хариуцдаг бол өгөөжийн нөхцөл хангагдаж болох юм.
  - (б) Байгууллага нь нөгөө байгууллагын хөрөнгийн хуваарилалтаас хэсэгчлэн авах бүрэн эрхтэй ба/буюу нөгөө байгууллагын зарим үүргийг хариуцдаг байж болно.
11. 10-р параграфт жагсаан харуулсан нэг буюу хэдэн нөхцлүүд оршин байхгүй тохиолдолд дараах хүчин зүйлс нь хяналтын оршин байдлыг дангаараа буюу хамтдаа илэрхийлэх магадлалтай байдаг.

*Бүрэн эрхийн үзүүлэлтүүд*

- (а) Байгууллага нь нөгөө байгууллагын үйл ажиллагааны болон капитал төсөвт хориг тавих чадвар боломжтой байх.
- (б) Байгууллага нь нөгөө байгууллагын удирдах зөвлөлийн шийдвэрт хориг тавих, хүчингүй болгох, өөрчлөх чадвар боломжтой байх.
- (в) Байгууллага нь нөгөө байгууллагын эрх бүхий албан тушаалтныг ажилд авах, өөрчлөх, чөлөөлөх чадвар боломжтой байх.
- (г) Нөгөө байгууллагын эрх, үүргийг хууль тогтоомжоор тогтоодог ба хязгаарладаг.

## САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

- (д) Байгууллага нь нөгөө байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогыг удирдах эрх олгодог уг нөгөө байгууллагын “алтан хувьцаа”<sup>1</sup> (буюу түүний адилтгах хувьцаа)-г эзэмшдэг.


### *Өгөөжийн үзүүлэлтүүд*

- (а) Байгууллага нь нөгөө байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийн эрхийн бичгийг тэдгээрт хандан нэвтрэх байнгын эрхийн хамт шууд буюу шууд бусаар эзэмшдэг.
- (б) Байгууллага нь нөгөө байгууллагын татан буулгалт болон татан буулгалтаас бусад хуваарилалтын үед түүний цэвэр хөрөнгө/өмчийн мэдэгдэхүйц хэсгийг авах эрхтэй байх.
- (в) Байгууллага нь өөрийн зорилтуудыг биелүүлэхдээ хамтран ажиллуулахаар нөгөө байгууллагыг чиглүүлэх чадвар боломжтой байх.
- (г) Байгууллага нь нөгөө байгууллагын үлдэх өр төлбөрийн хувьд хариуцлага хүлээдэг байх.
12. Нөгөө байгууллагад хяналт тогтоох үндсэн алхамуудыг дараах схемд харуулав. Үүнийг энэ Хавсралтын 1-11-р параграфын хамт уншвал зохино.

---

<sup>1</sup> “Алтан хувьцаа” нь эзэмшигчийн өмчлөлийн хувь оролцоо буюу удирдах зөвлөл дэх төлөөлөлтэй хэвийн холбоотойгоос ерөнхийдөө илүү давсан, тусгай бүрэн эрх буюу эрхийг эзэмшигчдээ олгодог хувьцааны ангийг илэрхийлдэг.

### Санхүүгийн тайлагналын зорилгоор өөр байгууллагад хяналт тогтоох



13. Хяналтанд буй байгууллагын үйл ажиллагаа нь уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх бусад байгууллагуудын үйл ажиллагаатай ижил төсөөтэй биш тухайлбал, УҮГ-ыг төсвийн байгууллагуудтай нэгтгэх тохиолдолд тэрхүү байгууллагыг зарим үед нэгтгэлд оруулахгүй хасдаг. Хяналтанд буй ийм байгууллагуудыг нэгтгэж, тэдгээр хяналтанд буй байгууллагуудын янз бүрийн үйл ажиллагааны талаар тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд нэмэлт мэдээллийг тодруулах нь илүү сайн мэдээллээр хангадаг учраас энэ үндэслэлээр нэгтгэлээс хасахыг зөвтгөн сайшаахгүй.



# **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ТАНИЛЦУУЛГА-2017 ОНД ГАРГАСАН**

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ) нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартууд (УСНББОУС-ууд) гэж нэрлэгдэх, улсын секторын байгууллагуудад зориулсан нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг боловсруулдаг. Улс орнуудын хооронд тууштай ба зэрэгцүүлэгдэх санхүүгийн мэдээлэлтэй болсноор мэдэгдэхүйц үр өгөөжтэй гэдгийг УСНББОУСЗ нь хүлээн зөвшөөрдөг бөгөөд эдгээр үр өгөөжийг хэрэгжүүлэх боломжтой болоход УСНББОУС-ууд гол үүрэг гүйцэтгэнэ гэж найддаг. УСНББОУСЗ нь өөрийн Саналын Төслүүд ба Зөвлөлдөх Баримт Бичгүүдэд тусгасан саналуудад засгийн газрууд болон үндэсний стандарт тогтоогч нар санал шүүмж өгөх замаар Стандартын хөгжилд оролцохыг хүчтэй дэмждэг.

УСНББОУСЗ нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн болон аккруэл суурьт санхүүгийн тайлагналыг зохицуулах УСНББОУС-уудыг гаргадаг.

Засгийн газрууд нь УСНББОУС-уудыг дагаж мөрдсөнөөр дэлхий даяарх улсын секторын байгууллагуудын тайлагнаж буй санхүүгийн мэдээллийн чанар ба зэрэгцүүлэгдэх байдлын аль аль нь сайжрах юм. Өөрсдийн улс оронд нягтлан бодох бүртгэлийн стандартууд ба санхүүгийн тайлагналын заавруудыг боловсруулан гаргах засгийн газруудын болон үндэсний стандарт тогтоогчдын эрхийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. Энэхүү Стандарт нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурьт санхүүгийн тайлагналын тууштай ба зэрэгцүүлэгдэх байдлыг сайжруулах чухал алхам гэж гэж УСНББОУСЗ үздэг бөгөөд энэ Стандартыг дагаж мөрдөхийг дэмждэг. Санхүүгийн тайлан нь энэхүү УСНББОУС-ын Нэгдүгээр хэсэгт заасан бүх шаардлагуудтай нийцсэн зөвхөн тийм тохиолдолд түүнийг энэ УСНББОУС-тай нийцсэн гэж тодорхойлох хэрэгтэй.

Засгийн газрууд нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт шилжих ба нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг хэрэглэж буй байгууллагууд мөрдөхөд зориулан бэлтгэсэн УСНББОУС-уудтай өөрийн үндэсний шаардлагуудыг уялдуулахыг УСНББОУСЗ дэмждэг. Ирээдүйн тодорхой хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг мөрдөх санаа зорилго бүхий байгууллагууд нь УСНББОУСЗ-ийн бусад хэвлэл материалыг, тухайлбал Сургалтын материал 14, *Нягтлан Бодох Бүртгэлийн Аккруэл Суурьт Шилжилт: Засгийн Газрууд болон Засгийн Газрын Байгууллагуудад Зориулсан Удирдамж*-ийг ач холбогдолтой гэж үзэж болох юм.

# УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ: НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ-2017 ОНД ГАРГАСАН

## Стандартын бүтэц

Энэ Стандарт нь хоёр хэсгээс бүрдэнэ:

- Нэгдүгээр хэсгийг заавал дагаж мөрдөх ёстой. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу нийтлэг зорилготой санхүүгийн тайлан бэлтгэж буй бүх байгууллагуудын дагаж мөрдөх шаардлагуудыг тогтоодог. Мөн энэ нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг тодорхойлж, санхүүгийн тайлан болон түүний дэмжих тэмдэглэл дэх мэдээллийн тодруулгад тавигдах шаардлагуудыг тогтоох бөгөөд тайлагналын олон тооны тусгай асуудлуудыг зохицуулдаг. Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, *“Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал”*-ын дагуу тайлагнах шаардлагатай бүх байгууллагууд нь Стандартын энэ хэсэгт заасан шаардлагуудыг дагаж мөрдөх ёстой.
- Хоёрдугаар хэсгийг заавал дагаж мөрдөх албагүй. Энэ нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд өөрийн санхүүгийн тайлангийн ач холбогдолтой байдлыг сайжруулах, түүнчлэн санхүүгийн тайлагналын аккруэл суурь ба аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжихэд дэмжлэг үзүүлэхийн тулд улсын секторын байгууллага мөрдөхийг сайшаан дэмжсэн нягтлан бодох бүртгэлийн нэмэлт бодлого, тодруулгыг тогтоосон.
- Мөнгөн суурьт УСНББОУС-ыг 2003 оны 01 дүгээр сард гаргасан. Төсвийн мэдээллийн толилуулгыг зохицуулах нэмэлт шаардлагууд болон сайшаан дэмжилтээр 2006 онд, харин гадаад тусламжийн толилуулгыг зохицуулах нэмэлт шаардлагууд болон сайшаан дэмжилтээр 2007 онд уг УСНББОУС-ыг шинэчлэн баяжуулсан.
- Хянан засварласан, Мөнгөн суурьт УСНББОУС-ыг 2017 онд гаргасан. Тэдгээр хянан засварлалт нь дараах зорилготой байсан:
  - (а) Нэгтгэл, гадаад тусламж, гуравдагч талын төлбөрийг зохицуулж буй одоогийн шаардлагуудын улмаас Мөнгөн суурьт УСНББОУС-ын мөрдөлтөнд учруулж байгаа хориг саадыг арилгах. Тухайлбал; гадаад тусламж ба гуравдагч талын төлбөрийн талаархи нэгтгэсэн санхүүгийн тайлангийн болон тодруулгын мэдээллийг тус УСНББОУС-ын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэний дагуу бэлтгэхийн тулд энэхүү УСНББОУС-ын Нэгдүгээр хэсгийн шаардлагуудыг шинэчлэн тогтоох;

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- (б) Энэ Стандарт дахь шаардлагууд болон сайшаан дэмжилтүүд нь адилтгах, аккруэл суурьт УСНББОУС-ын шаардлагуудаас өөр байснаар мөнгөн суурийн мөрдөлтийг тусган илэрхийлэхэд тохиромжтой байхаас бусад тохиолдолд тэдгээр Стандартын шаардлагууд харилцан зөрчилдөөгүй гэдгийг ханган магадлах; ба
- (в) УСНББОУСЗ-ийн стандарт тогтоох ерөнхий стратегид энэхүү Мөнгөн суурьт УСНББОУС-ын үзүүлэхийг зорьж буй үүрэг нь түүнийг мөрдсөнөөр дуусах биш, харин аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөх цаашдын замд юуны өмнө нэг алхам болно гэдгийг тодруулж өгөх.

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

### АГУУЛГА

	Танилцуулга	
	Стандартын бүтэц	
	<b>Нэгдүгээр хэсэг: Шаардлагууд</b>	
	Зорилт	
		Параграф
1.1	Шаардлагуудын цар хүрээ	1.1.1–1.1.6
1.2	Мөнгөн суурь	1.2.1–1.2.10
	Тодорхойлолт	1.2.1–1.2.10
	Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь	1.2.2
	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	1.2.3–1.2.5
	Тайлагнагч байгууллагын хянаж буй мөнгөн хөрөнгө	1.2.6–1.2.9
	Байгууллагын хяналт	2.10
1.3	Толилуулга ба тодруулгын шаардлагууд	1.3.1–1.3.33
	Тодорхойлолт	1.3.1–1.3.3
	Санхүүгийн тайлан	1.3.4–1.3.11
	Мөнгөн орлого, зарлагын тайланд толилуулах мэдээлэл	1.3.12–1.3.24
	Ангилал	1.3.17–1.3.18
	Мөрийн зүйлс, гарчиг, дэд дүн	1.3.19
	Цэвэр дүнгээр тайлагнах	1.3.20–1.3.24
	Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тайлбар тэмдэглэл	1.3.25–1.3.33
	Тэмдэглэлийн бүтэц	1.3.25–1.3.26
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт ба тодруулга	1.3.27–1.3.33
1.4	Ерөнхий асуудлууд	1.4.1–1.4.25
	Тайлант үе	1.4.1–1.4.3
	Цаг хугацаандаа байх	1.4.4
	Зөвшөөрсөн өдөр	1.4.5–1.4.6
	Байгууллагын тухай мэдээлэл	1.4.7–1.4.8
	Мөнгөний үлдэгдэлд болон зээл авахад тавигдах хязгаарлалт	1.4.9–1.4.12
	Толилуулгын тууштай байдал	1.4.13–1.4.15
	Зэрэгцүүлэгдэх мэдээлэл	1.4.16–1.4.20
	Санхүүгийн тайлангийн ялган тодорхойлолт	1.4.21–1.4.25
1.5	Алдааны засварлалт	1.5.1–1.5.5
1.6	Гадаад валют	1.6.1–1.6.8
	Тодорхойлолт	1.6.1
	Гадаад валютаарх мөнгөн орлого, зарлага, үлдэгдлийн бүртгэлийн арга	1.6.2–1.6.8
1.7	Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга	1.7.1–1.7.46
	Тодорхойлолт	1.7.1–1.7.7
	Батлагдсан төсөв	1.7.2–1.7.4
	Анхны болон тодотгосон төсөв	1.7.5–1.7.6
	Гүйцэтгэлийн дүн	1.7.7

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

	Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлсэн толилуулга	1.7.8–1.7.32
	Цар хүрээ	1.7.9–1.7.10
	Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт	1.7.11–1.7.16
	Толилуулга	1.7.17–1.7.19
	Нэгтгэлийн түвшин	1.7.20–1.7.22
	Анхны төсвөөс тодотгосон төсөв болгох өөрчлөлт	1.7.23–1.7.24
	Зэрэгцүүлэгдэх суурь	1.7.25–1.7.30
	Олон жилийн төсөв	1.7.31–1.7.32
	Төсвийн суурь, хугацаа, цар хүрээний тэмдэглэл тодруулга	1.7.33–1.7.40
	Зэрэгцүүлэгдэх сууриар тусгасан гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайлан дахь гүйцэтгэлийн дүнгийн хоорондох тохируулга	1.7.41–1.7.46
1.8	Нэгдүгээр хэсгийн хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилтийн нөхцлүүд	1.8.1–1.8.13
	Шилжилтийн нөхцлүүд	1.8.1–1.8.4
	Хүчин төгөлдөр болох хугацаа	1.8.5–1.8.6
	Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-аас татгалзах	1.8.7–1.8.10
	Хүчингүй болгосон, Мөнгөн суурьт УСНББОУС-ыг мөрддөг байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1.8.11–1.8.13
	Дүгнэлтийн үндэслэл	
	Хавсралт 1: Энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн шаардлагуудын үлгэрчилсэн жишээ	
	Хоёрдугаар хэсэг: Сайшаан дэмжсэн нэмэлт тодруулга	
2.1	Сайшаан дэмжсэн нэмэлт тодруулга	2.1.1–2.1.103
	Тодорхойлолт	2.1.1–2.1.2
	Ирээдүйн эдийн засгийн үр буюу үйлчилгээний чадавхи	2.1.2
	Тасралтгүй байх суурь	2.1.3–2.1.5
	Туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээ	2.1.6–2.1.13
	Орлогын цуглуулалт	2.1.9–2.1.11
	“Дамжуулах” мөнгөн гүйлгээ	2.1.12
	Шилжүүлгийн төлбөр	2.1.13
	Мөнгөн гүйлгээний гол ангиудын тодруулга	2.1.14–2.1.21
	Холбоотой талуудын тодруулга	2.1.22–2.1.23
	Хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал болон төсвийн зэрэгцүүлэлтийн тодруулга	2.1.24–2.1.32
	Төсвийн зэрэгцүүлэлт	2.1.28–2.1.32
	Нэгтгэсэн санхүүгийн тайлан	2.1.33–2.1.61
	Тодорхойлолт	2.1.33
	Эдийн засгийн нэгдмэл байгууллага	2.1.34–2.1.36
	Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн цар хүрээ	2.1.37–2.1.46
	Нэгтгэсэн санхүүгийн тайланд шилжилт	2.1.47–2.1.49
	Нэгтгэлийн горим	2.1.50–2.1.52

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

	Нэгтгэлийн тодруулга	2.1.53–2.1.56
	Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны бусад нэгжүүдийн олж эзэмшилт ба данснаас хасалт	2.1.57–2.1.61
	Хамтын хэлэлцээр	2.1.62–2.1.63
	Хэт инфляцитай эдийн засгийн үеийн санхүүгийн тайлагнал	2.1.64–2.1.76
	Санхүүгийн тайлангийн дахин илэрхийлэлт	2.1.66–2.1.71
	Зэрэгцүүлэгдэх мэдээлэл	2.1.72
	Нэгтгэсэн санхүүгийн тайлан	2.1.73–2.1.74
	Үнийн ерөнхий индексийн сонголт ба хэрэглээ	2.1.75–2.1.76
	Байгууллагын өмнөөс гуравдагч талын хийсэн төлбөр	2.1.77–2.1.81
	Гадаадын болон бусад тусламж хүлээн авагчид	2.1.82–2.1.103
	Тодорхойлолт	2.1.82
	Тусламж	2.1.83–2.1.89
	Хүлээн авсан гадаад тусламж	2.1.90
	Хүлээн авсан бусад тусламж	2.1.91
	Хүлээн авсан гадаадын болон бусад тусламж	2.1.92–2.1.99
	Хүлээн авсан бараа, үйлчилгээ	2.1.100–2.1.103
2.2	Санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжиж буй засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагууд	2.2.1–2.2.9
	Мөнгөн орлого, зарлагын тайлангийн толилуулга	2.2.1–2.2.3
	Нэгтгэсэн санхүүгийн тайлан – Эдийн засгийн нэгдмэл байгууллага	2.2.4–2.2.6
	Мөнгөн суурьт УСНББОУС-ын дагуу шаардсан ба дэмжсэн тодруулга	2.2.7
	УСНББОУС 33, <i>Аккруэл Суурьт УСНББОУС-ыг Анх Удаа Мөрдөх</i>	2.2.8–2.2.9
	Дүгнэлтийн үндэслэл	
	Хавсралт 2: Энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн зарим тодруулгын үлгэрчилсэн жишээ	
	Хавсралт 3: УСНББОУС 2, <i>Мөнгөн Гүйлгээний Тайлан</i> -гаар шаардсан загвараар бэлтгэсэн Мөнгөн орлого, зарлагын тайлангийн толилуулга	
	Хавсралт 4: Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайланд тусгасан мэдээллийн чанарын шинжүүд	

## ХАВСРАЛТ 1

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ШААРДЛАГУУД

*Энэ Стандартын Нэгдүгээр хэсэгт нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу тайлагналын шаардлагуудыг заасан.*

*Эрх бүхий шаардлагуудыг тод хар, ташуу хэлбэрээр илэрхийлсэн. Эрх бүхий шаардлагууд гэдгийг анхааруулан илэрхийлэхийн тулд “ёстой/хэрэгтэй” гэсэн хэллэгийг ашигласан. Ийм шаардлагуудыг энэ Стандартад энгийн хэлбэрээр бичсэн тайлбар параграфууд болон “Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил”-ын хамт уншвал зохино. Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартыг материаллаа бус зүйлсэд мөрдөх санаа зорилгогүй болно.*

### Зорилт

Энэ Стандартын зорилго нь нийтлэг зорилготой санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу толилуулах арга хэлбэрийг тодорхойлоход оршино.

Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилт нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (НЗСТ) ба бусад нийтлэг зорилготой тайлан илтгэлийн (НЗТИ) хэрэглэгчдэд ач холбогдолтой, уг байгууллагын талаархи мэдээллээр хангах явдал юм. Байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдлийн талаархи мэдээлэл нь хариуцлагын зорилгын хувьд зайлшгүй шаардлагатай бөгөөд ирээдүйд зохих мөнгө бий болгох тухайн байгууллагын чадвар, түүнчлэн мөнгөний магадлалт эх үүсвэр ба ашиглалтын талаархи үнэлгээнд ач холбогдолтой орц өгөгдлөөр хангадаг. Мөнгөн нөөцийн хуваарилалт ба байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлын талаархи шийдвэрийг гаргаж, үнэлэхийн тулд хэрэглэгчид нь мөнгөн орлого, мөнгөн зарлагын цаг хугацаа болон магадлалт байдлын хувьд ойлголттой байх шаардлагатай юм.

Энэ Стандартын шаардлагууд болон сайшаан дэмжсэн зүйлсийг даган мөрдөх нь тухайн байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдлийн талаархи дэлгэрэнгүй ба ил тод санхүүгийн тайлагналыг бэхжүүлэн сайжруулах юм. Энэ нь тухайн байгууллагын өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайлантай болон нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг мөрддөг бусад байгууллагуудын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэгдэх байдлыг мөн сайжруулна.

### Мөнгөн суурьт УСНББОУС-ын үүрэг

Аккруэл УСНББОУС-ыг мөрдсөнөөр уг санхүүгийн тайлагналын зорилтуудад хүрнэ гэж УСНББОУСЗ үздэг. Иймээс засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагууд нь аккруэл УСНББОУС-ын шаардлагуудад нийцсэн, санхүүгийн тайлан толилуулахыг УСНББОУСЗ сайшаан дэмждэг. Гэвч ийм эцсийн үр дүнд хүрэхийн тулд зарим улс орнуудын хувьд шилжилтийн үйл явц зайлшгүй шаардлагатай байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ыг мөрдөх шилжилтэнд туслалцаа үзүүлэх завсрын алхам байдлаар энэхүү Мөнгөн суурьт УСНББОУС-ыг боловсруулсан. Үүнийг боловсруулснаар дуусвар болохгүй. Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн тодруулгын үүрэг нь санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд байгууллага шилжихэд дэмжлэг үзүүлэх явдал юм.

Санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжихдээ сонгосон арга зам нь тухайн улс орны нөхцөл байдлыг тусгадаг тул улс орон бүрд өөр байж болох юм. Шилжилтийн тодорхой арга замыг баримтлах хэрэгтэй гэдгийг, эсвэл байгууллагууд нь шилжилтийн үйл явцын эхний алхам болгон энэхүү Мөнгөн суурьт УСНББОУС-ыг заавал мөрдөх ёстой гэж УСНББОУСЗ тусгайлан заагаагүй.



## 1.1 Шаардлагуудын цар хүрээ

1.1.1 Дараах бүх шалгуурыг хангасан улсын секторын байгууллагуудад<sup>1</sup> мөрдөхийн тулд энэхүү УСНББОУС-ыг төлөвлөн зохиомжилсон:

- (а) Олон нийтэд өгөөж хүртээх ба/буюу орлого, баялагийг дахин хуваарилахын тулд үйлчилгээ үзүүлэх<sup>2</sup> хариуцлага хүлээдэг;
- (б) Өөрсдийн үйл ажиллагааг татвар, засгийн газрын бусад түвшнээс авсан шилжүүлэг, нийгмийн даатгалын шимтгэл, өр, хураамжаар ихэвчлэн шууд буюу шууд бусаар санхүүжүүлдэг;
- (в) Ашиг олох үндсэн зорилгогүй.

1.1.2 ***Энэ Стандартад тодорхойлсон нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (санхүүгийн тайлан)-гаа бэлтгэж, толилуулдаг улсын секторын байгууллага нь өөрийн жилийн санхүүгийн тайлангийн толилуулгад энэ Стандартын Нэгдүгээр хэсэгт заасан шаардлагуудыг мөрдөх хэрэгтэй.***

1.1.3 Өөрсдийн мэдээллийн тусгай хэрэгцээ шаардлагыг хангахын тулд санхүүгийн тайланг түүнд тохируулан нийцүүлэхийг шаардах байр суурьгүй тийм үйлчилгээ хүлээн авагчид, нөөцөөр хангагчид болон эдгээр хэрэглэгчдийн төлөөлөгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахын тулд нийтлэг зорилготой санхүүгийн тайланг үндсэндээ бэлтгэдэг. Үйлчилгээ хүлээн авагчид ба тэдний төлөөлөгчид, нөөцөөр хангагчид ба тэдний төлөөлөгчид нь иргэд, оршин суугчид, татвар төлөгчид, төлбөр хураамж төлөгчид, хууль тогтоох (буюу адилтгах) байгууллагын гишүүд, парламент (буюу адилтгах төлөөллийн байгууллагын) гишүүд, донор агентлагууд, зээлдүүлэгчид, түүнчлэн засгийн газрын үйлчилгээнд зориулан нөөцөөр хангах буюу түүнээс өгөөж хүртдэг бусад талууд юм. Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчдын мэдээллийн хэрэгцээг хангахын тулд бэлтгэсэн нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь мөн бусад талуудад ач холбогдолтой мэдээллийг бүрдүүлдэг байж болно. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь жилийн тайлан илтгэл гэх мэт нийтийн зориулалттай бусад баримт бичгийн бүрэлдэхүүнд оруулан эсвэл тусад нь толилуулдаг санхүүгийн тайланг агуулсан байна. Энэ Стандартын зорилгын хувьд өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд “нийтлэг зорилготой санхүүгийн тайлан” ба “санхүүгийн тайлан” гэсэн нэр томъёог харилцан бие биенийгээ орлох утгатайгаар ашигласан.

1.1.4 Тайлагнагч байгууллага нь санхүүгийн тайланг толилуулдаг бие даасан байгууллага байна, эсвэл хяналт тавигч байгууллага нь группын санхүүгийн

<sup>1</sup> УСНББОУС-ыг мөрдөж болох улсын секторын янз бүрийн байгууллагуудыг *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал*-ын 1.8-р параграфт тодорхойлсон.

<sup>2</sup> Үйлчилгээ нь бараа, үйлчилгээ, түүнчлэн улсын секторын бусад байгууллагуудад үзүүлэх бодлогын зөвлөгөөг агуулсан байна.

тайланг толилуулах сонголт хийсэн тохиолдолд тайлагнагч байгууллага нь нэг байгууллага мэтээр санхүүгийн тайлангаа толилуулдаг хяналт тавигч байгууллага болон хяналтанд буй нэг буюу хэд хэдэн байгууллагуудаас бүрдэж болох юм. Улсын секторын тайлагнагч байгууллага (цаашид өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд тайлагнагч байгууллага эсвэл байгууллага гэж нэрлэнэ) нь засгийн газар болон улсын секторын бусад байгууллага, хөтөлбөр эсвэл санхүүгийн тайланг зориулан бэлтгэдэг үйл ажиллагааны тодорхойлж болох талбар байдаг. Санхүүгийн тайланг зориулан бэлтгэдэг байгууллагууд болон үйл ажиллагааны талаархи зарим мэдээллийн тодруулга хийхийг энэ Стандартын 1.4.7-р параграфээр шаардсан байдаг.

1.1.5 Энэхүү Стандартыг бие даасан байгууллагын санхүүгийн тайланд, түүнчлэн хяналт тавигч байгууллага болон хяналтанд буй нэг буюу хэд хэдэн байгууллагуудаас бүрдэх тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланд нэгэн адил мөрдөнө. Тайлагнагч байгууллагын хянаж буй мөнгийг тусган хүлээн зөвшөөрдөг мөнгөн орлого, зарлагын тайлангийн бэлтгэлт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга, тайлбар тэмдэглэлийн хувьд энэ Стандарт шаардлагатай юм.

1.1.6 *Энэхүү Стандартын Нэгдүгээр хэсгийн шаардлагуудтай нийцсэн санхүүгийн тайлан бүхий байгууллага нь энэ тухай тодруулга хийх хэрэгтэй. Санхүүгийн тайлан нь энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн бүх шаардлагуудтай нийцсэн биш л бол түүнийг тус Стандарттай нийцсэн гэж илэрхийлэх ёсгүй.*

## 1.2 Мөнгөн суурь

### Тодорхойлолт

1.2.1 *Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:*

**Мөнгө** нь бэлэн мөнгө, харилцах данс болон мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бүрдэнэ.

**Мөнгөн суурь** гэдэг нь ажил гүйлгээ ба бусад үйл явдлыг зөвхөн мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн үед хүлээн зөвшөөрдөг нягтлан бодох бүртгэлийн суурь юм.

**Мөнгөтэй адилтгах хөрөнгө** нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, хөрвөх чадвар өндөртэй хөрөнгө оруулалт юм.

**Мөнгөн гүйлгээ** нь мөнгөний орлогын болон зарлагын урсгал юм.

**Мөнгөн зарлага** нь мөнгөний зарлагын урсгал юм.

**Мөнгөөр орлого** нь мөнгөний орлогын урсгал юм.

**Мөнгөний хяналт** нь байгууллага өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд мөнгийг ашиглах эсвэл өөр бусад байдлаар

***мөнгөнөөс өгөөж хүртэх бөгөөд тэрхүү өгөөжид бусад талуудыг хандан нэвтрүүлэхгүй байх буюу хандан нэвтрэлтийг зохицуулж чадах тохиолдолд үүсдэг.***

***Байгууллагын хяналт: Байгууллага нь бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй бөгөөд уг бусад байгууллага дахь бүрэн эрхээрээ дамжуулан тэдгээр өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэх чадвар, боломжтой бол тухайн байгууллага нь тэрхүү бусад байгууллагыг хянана.***

***Хяналтанд буй байгууллага гэдэг нь өөр байгууллагын (хяналт тавигч байгууллага гэж нэрлэдэг) хяналтанд байдаг байгууллага юм.***

## **Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь**

- 1.2.2 Байгууллага нь зөвхөн мөнгө (үүн дотроо, мөнгөтэй адилтгах хөрөнгө) хүлээн авсан эсвэл төлсөн үед нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь нь ажил гүйлгээ болон үйл явдлыг хүлээн зөвшөөрдөг. Мөнгөн суурийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан нь тухайн тайлант үеийн туршид бий болсон мөнгөний эх үүсвэр, мөнгийг ашиглан зарцуулсан зорилго, тайлангийн өдрөөрх мөнгөний үлдэгдлийн талаархи мэдээллээр хэрэглэгчдийг хангадаг. Санхүүгийн тайлан дахь хэмжилтийн анхаарах зүйл нь мөнгөний үлдэгдлүүд ба тэдгээрийн өөрчлөлт юм. Санхүүгийн тайлангийн тэмдэглэл нь өглөг, зээл гэх мэт өр төлбөр болон авлага, хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгө гэх мэт мөнгөн бус зарим хөрөнгийн талаархи нэмэлт мэдээллээр хангаж болох юм.

## **Мөнгөтэй адилтгах хөрөнгө**

- 1.2.3 Хөрөнгө оруулалтын буюу бусад зорилго гэхээс илүүтэйгээр мөнгөний богино хугацааны хариуцлагаа биелүүлэх зорилгоор мөнгөтэй адилтгах хөрөнгийг эзэмшдэг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийн шалгуурыг хангахын тулд хөрөнгө оруулалт нь мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой бөгөөд үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй байх ёстой. Иймээс хөрөнгө оруулалт нь богино хугацаатай, тодруулбал; худалдан авч эзэмшсэнээс хойш 3 сар буюу түүнээс богино хугацаанд дуусгавар болох хугацаатай байх зөвхөн тийм тохиолдолд мөнгөтэй адилтгах хөрөнгийн шалгуурыг ихэвчлэн хангадаг. Мөн чанарын хувьд мөнгөтэй адилтгах хөрөнгө байхаас бусад тохиолдолд өмчийн хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй.
- 1.2.4 Банкны зээлийг ерөнхийдөө мөнгөний орлогын гүйлгээ үүсэхэд хүргэдэг гэж үздэг. Гэвч шаардлагаар шууд буцаан төлөгдөх банкны овердрафт нь зарим улс оронд тухайн байгууллагын мөнгөн хөрөнгийн удирдлагын салшгүй нэг хэсэг болдог. Энэ тохиолдолд банкны овердрафтыг мөнгөн хөрөнгийн бүрэлдэхүүнд оруулдаг. Банкны ийм хэлцлүүдийн онцлог шинж нь банкны дансны үлдэгдлийг эерэг дүнгээс сөрөг дүн болж байнга хэлбэлзэхэд хүргэдэг явдал юм.

- 1.2.5 Мөнгийг бүрдүүлж буй зүйлс нь тухайн байгууллагын хянаж буй мөнгөний нэмэгдэлт эсвэл бууралт гэхээсээ илүүтэйгээр түүний мөнгөн хөрөнгийн удирдлагын бүрэлдэхүүн хэсэг болдог тул тэдгээр зүйлсийн хоорондох хөдөлгөөнийг мөнгөн гүйлгээнд оруулахгүй. Өөрийн илүүдэл мөнгөөр мөнгөтэй адилтгах хөрөнгөнд хийх хөрөнгө оруулалт нь мөнгөн хөрөнгийн удирдлагад хамаарна.

#### **Тайлагнагч байгууллагын хянаж буй мөнгөн хөрөнгө**

- 1.2.6 Байгууллага нь өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд мөнгийг ашиглах эсвэл өөр бусад байдлаар мөнгөнөөс өгөөж хүртэх бөгөөд тэрхүү өгөөжид бусад талуудыг хандан нэвтрүүлэхгүй байх буюу хандан нэвтрэлтийг зохицуулж чадах тохиолдолд мөнгийг хянадаг. Байгууллага өөрийн цуглуулсан эсвэл түүнд хуваарилсан буюу олгосон мөнгийг үйл ажиллагааны зорилтуудыг санхүүжүүлэх, капитал хөрөнгийг худалдан авах, өрөө буцаан төлөхөд ашиглаж чадах тохиолдолд тухайн байгууллага нь мөнгийг хянадаг.

- 1.2.7 Байгууллагын банкин дахь харилцах дансанд байршуулсан мөнгийг тухайн байгууллага хянадаг. Зарим тохиолдолд засгийн газрын байгууллага нь:

- (а) Өөрийн засгийн газрын (болон бусад байгууллагын) өмнөөс цуглуулсан мөнгийг нэгтгэсэн орлогын буюу засгийн газрын бусад ерөнхий дансанд шилжүүлэхээс өмнө, өөрийн банкин дахь харилцах дансанд байршуулдаг; ба
- (б) Өөрийн засгийн газрын өмнөөс гуравдагч талд шилжүүлэх ёстой мөнгийг тухайн зөвшөөрөгдсөн хүлээн авагчид шилжүүлэхээс өмнө, өөрийн банкин дахь харилцах дансанд эхлээд байршуулдаг.

Эдгээр тохиолдолд байгууллага нь мөнгийг нэгтгэсэн орлогын буюу засгийн газрын хяналтанд буй бусад банкны дансанд эсвэл гуравдагч талд шилжүүлэхээс өмнө, өөрийн банкны харилцах дансанд байлгах зөвхөн тэрхүү хугацаанд хянадаг. Тайлангийн өдрөөр тухайн байгууллага эзэмшиж байгаа боловч ашиглах боломжгүй буюу гаднын хязгаарлалт тавигдсан мөнгөний үлдэгдлийн талаар тодруулга хийхийг 1.4.9-р параграфтаар шаардсан байдаг. Бусад байгууллагуудын өмнөөс тухайн байгууллагын туслалцаа үзүүлсэн мөнгөн гүйлгээний бүртгэлийн аргын талаархи нэмэлт заавар удирдамжийг энэ Стандартын Хоёрдугаар хэсгийн 2.1.6-2.1.13-р параграфуудад тусгасан.

- 1.2.8 Зарим улс оронд, “нэг данс”-ны суурь гэж ихэвчлэн нэрлэдэг, төвлөрсөн төрийн сангийн чиг үүргээр дамжуулан засгийн газар нь өөрийн бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын зарлагыг удирддаг. Ийм зохицуулалтын дагуу бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагууд нь өөрийн банкны дансыг хянадаггүй. Харин төвлөрсөн төрийн сангийн чиг үүрэг нь бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын өмнөөс банктай адил үүрэг гүйцэтгэдэг. Төрийн сангийн нэг дансаар дамжуулан хийх тухайн байгууллагын мөнгөн орлогын болон мөнгөн зарлагын гүйлгээ, уг дансанд эзэмшиж буй мөнгөний үлдэгдлийг 1.3.4-р параграфын шаардлагуудын дагуу мөнгөн орлого, зарлагын

тайланд тайлагнана. Төвлөрсөн төрийн сангийн чиг үүргийн зүгээс авч үзвэл, бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын өмнөөс хийсэн төлбөрийг тэдгээрийн дансдын хүрээн дэх өөрчлөлт байдлаар бүртгэнэ – энэ нь өөрийн үйлчлүүлэгчдийн өмнөөс хийсэн төлбөрийг тайлагнахдаа банкны мөрддөг арга хандлагыг тусгадаг.

- 1.2.9 Зарим тохиолдолд банкны данс (дансууд)-ыг хянадаг байгууллага нь үйл ажиллагааны бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын өмнөөс төлбөрийг тус данснаас хийж, төвлөрсөн төрийн сангийн чиг үүргийг гүйцэтгэдэг. Энэ тохиолдолд тэдгээр банкны дансанд орсон шилжүүлэг ба уг данснаас хийгдсэн төлбөр нь үйл ажиллагааны бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын өмнөөс уг төв байгууллагын гүйцэтгэж буй мөнгөн орлого, зарлагыг тусгадаг. Бусад байгууллагуудын өмнөөс тухайн байгууллагын гүйцэтгэж буй ажил гүйлгээнээс үүсдэг бөгөөд анхдагч санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг мөнгөн орлого, зарлагыг цэвэр дүнгээр тайлагнаж болно гэдгийг 1.3.13-р параграфт тусгайлан заасан. Тайлангийн өдрөөр тухайн байгууллага эзэмшиж байгаа боловч ашиглах боломжгүй буюу гаднын хязгаарлалт тавигдсан мөнгөний үлдэгдлийн талаар тодруулга хийхийг 1.4.9-р параграфтаар шаардсан байдаг.

### **Байгууллагын хяналт**

- 1.2.10 Засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагууд нь маш олон тооны байгууллагыг, үүн дотроо засгийн газрын хэлтэс газрууд, агентлагууд, улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудыг хянадаг байж болно. Бие даасан байгууллага буюу хяналт тавигч байгууллага, түүнчлэн түүний хяналтанд буй бүх эсвэл зарим байгууллагуудаас бүрдэх тайлагнагч байгууллагын хувьд санхүүгийн тайланг бэлтгэж болох юм. Хяналт тавигч байгууллагууд нь тодорхойлсон зарим нөхцөл байдлаас бусад тохиолдолд тухайн хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй бүх байгууллагуудыг агуулсан, нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэж, толилуулахыг энэ Стандарт (2.1.37-р параграф)-аар сайшаан дэмждэг боловч заавал шаарддаггүй. Нэг байгууллага нь санхүүгийн тайлагналын зорилгоор нөгөө байгууллагыг хянадаг эсэхийг үнэлэхдээ харгалзан үзэх хүчин зүйлсийг УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан-д* заасан.

## **1.3 Толилуулга ба тодруулгын шаардлагууд**

### **Тодорхойлолт**

- 1.3.1 ***Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:***

***Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик юм.***

***Материаллаг байдал:*** Мэдээллийн орхигдуулалт буюу буруу илэрхийлэлт нь байгууллагын хариуцлагын биелэлт эсвэл тухайн тайлант үеийн хувьд бэлтгэсэн уг байгууллагын санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн шийдвэрт нөлөө үзүүлж чадахаар байвал түүнийг материаллаг гэж үзнэ. Материаллаг байдал нь байгууллага тус бүрийн тухайн тодорхой нөхцөл байдалд шүүн тунгаасан уг орхигдуулалт буюу буруу илэрхийлэлтийн шинж төрөл ба дүнгээс хамаардаг.

***Тайлангийн өдөр гэдэг нь тухайн санхүүгийн тайлангийн хамаарах тайлант үеийн сүүлчийн өдрийг хэлнэ.***

- 1.3.2 Маш олон тооны ажил гүйлгээг тэдгээрийн шинж төрөл эсвэл чиг үүргийн дагуу ангиудад нэгтгэн нийлүүлэх боловсруулалтын үр дүнд санхүүгийн тайланг бэлтгэдэг. Нэгтгэн нийлүүлэх ба ангилах боловсруулалтын эцсийн үе шат нь хураангуйлж, ангилсан мэдээний толилуулга бөгөөд энэ нь санхүүгийн тайланд эсвэл тэмдэглэлд тусгах мөрийн зүйлсийг бүрдүүлдэг. Хэрэв мөрийн зүйл нь дангаараа материаллаг биш бол түүнийг санхүүгийн тайланд эсвэл тэмдэглэлд тусгахдаа бусад мөрийн зүйлстэй нэгтгэн нийлүүлдэг. Санхүүгийн тайланд тусдаа толилуулах үндэслэл болохуйц хангалттай материаллаг биш зүйл нь тэмдэглэлд тусдаа толилуулахад хангалттай материаллаг байж болох юм.
- 1.3.3 Хэрэв үр дүнгийн мэдээлэл нь материаллаг бус бол Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын тодруулгын тусгай шаардлагуудыг биелүүлэх албагүй гэдгийг материаллаг байдлын зарчим илэрхийлдэг.

### **Санхүүгийн тайлан**

- 1.3.4 ***Байгууллага нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан нийтлэг зорилготой санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулах хэрэгтэй:***
- (а) ***Байгууллагын хянаж буй бүх мөнгөн орлого, зарлага болон мөнгөний үлдэгдлийг хүлээн зөвшөөрдөг мөнгөн орлого, зарлагын тайлан;***
  - (б) ***Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тайлбар тэмдэглэл; болон***
  - (в) ***Байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаг тохиолдолд энэ Стандартын 1.7.8-р параграфын дагуу тусдаа нэмэлт санхүүгийн тайлан эсвэл мөнгөн орлого, зарлагын тайланд төсвийн багана байдлаар харуулсан төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт.***
- 1.3.5 ***Байгууллага нь энэ Стандартад тодорхойлсон буюу 1.3.4(в) параграфт бусад байдлаар шаардсан нягтлан бодох бүртгэлийн мөнгөн сууриас өөр сууриар бэлтгэсэн мэдээллийг тодруулах сонголт хийсэн бол ийм мэдээллийг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулах хэрэгтэй.***

- 1.3.6 Санхүүгийн тайлан нь мөнгөн орлого, зарлагын тайлан, түүнчлэн байгууллагын хянаж буй мөнгөн орлого, зарлага, мөнгөний үлдэгдлийн талаархи нэмэлт мэдээллийг тодруулах бусад тайлангууд болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тэмдэглэлээс бүрдэнэ. Дээрх 1.3.4(а) параграфын шаардлагуудын дагуу, уг тайлагнагч байгууллагын хянаж буй зөвхөн мөнгөн орлого, зарлага болон мөнгөний үлдэгдлийг мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл бэлтгэж болох бусад тайланд ийм байдлаар хүлээн зөвшөөрнө. Дээрх 1.3.4(в) параграфын шаардлагуудын дагуу, санхүүгийн тайлан нь төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг нэмэлт санхүүгийн тайлан хэлбэрээр өөртөө агуулсан байж болно.
- 1.3.7 Санхүүгийн тайлан болон төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар зөвхөн бэлтгэсэн тохиолдолд байгууллага нь төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг мөнгөн орлого, зарлагын тайланд төсвийн нэмэлт багана байдлаар толилуулж болно гэж энэ Стандартын 1.7.17-р параграфт заасан. Санхүүгийн тайлан болон төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгээгүй тохиолдолд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тусдаа тайланг толилуулна.
- 1.3.8 Санхүүгийн тайлангийн тэмдэглэл нь тухайн санхүүгийн тайланд харуулсан дүнгүүдийн хүүрнэсэн тайлбар буюу илүү дэлгэрэнгүй задаргаа болон шинжилгээ, түүнчлэн нэмэлт мэдээллээс бүрддэг. Тэмдэглэл нь энэ Стандартаар тодруулахыг шаардсан ба сайшаан дэмжсэн мэдээллүүдээс бүрдэх бөгөөд үнэн зөв толилуулгад хүрэхэд болон хариуцлагатай байдлыг сайжруулахад шаардлагатай гэж үзсэн бусад тодруулгыг агуулсан байж болно.
- 1.3.9 Дээрх 1.3.4-р параграфт заасанчлан, байгууллага нь мөнгөн орлого, зарлагын тайлангаас гадна бусад тайланг өөрийн нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусган оруулахыг энэ Стандартаар хориглодоггүй. Иймээс, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь тухайлбал, дараах зүйлсийг тайлагнах нэмэлт тайлангуудыг агуулсан байж болно:
- (а) Нэгтгэсэн орлогын сан гэх мэт мөнгө сангийн гол ангиллуудын хувьд мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдлийг тайлагнах;
  - (б) Зээлийн эх үүсвэр ба ашиглан зарцуулалт, мөнгөн зарлагын шинж чанар ба төрлийн талаархи нэмэлт мэдээллээр хангах; эсвэл
  - (в) Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг харуулах.
- Дээрх 1.3.5-р параграфын шаардлагуудын дагуу, аливаа нэмэлт тайлан нь тухайн байгууллагын хянаж буй мөнгөн орлого, зарлага болон үлдэгдлийг зөвхөн тайлагнадаг.
- 1.3.10 Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг ашиглан тайлагнаж буй байгууллагууд нь мөнгөн суурьт нягтлан бодох бүртгэлийн дагуу хүлээн зөвшөөрдөггүй зүйлсийн талаархи мэдээллийг байнга цуглуулдаг. Цуглуулж болох мэдээллийн төрлийн жишээнд дараах зүйлсийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл хамаарна:

- (а) Авлага, өглөг, зээл ба бусад өр төлбөр, мөнгөн бус хөрөнгө, хуримтлагдсан орлого ба зардал;
  - (б) Баталгаа ба болзошгүй өр төлбөр;
  - (в) Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд ба үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилт.
- 1.3.11 Энэ Стандартын дагуу нийтлэг зорилготой санхүүгийн тайлангаа бэлтгэж буй байгууллагууд нь хэрэглэгчдэд тухайн мэдээлэл ач холбогдолтой байх магадлалтай тохиолдолд түүнийг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулж болно. Хийсэн тодруулгаа тодорхой тайлбарлах бөгөөд тодруулга нь шууд ойлгогдохуйц байвал зохино. Төсөвтэй хийсэн зэрэгцүүлэлтийг санхүүгийн тайланд тусгаагүй бол тэмдэглэл хэсэгт оруулж болно. Мөнгөн бус хөрөнгө ба өр төлбөрийн талаархи мэдээлэл, төсөвтэй хийсэн зэрэгцүүлэлтийг нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусган оруулахыг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн.

### **Мөнгөн орлого, зарлагын тайланд толилуулах мэдээлэл**

- 1.3.12 *Мөнгөн орлого, зарлагын тайланд тухайн тайлант үеийн дараах дүнгүүдийг толилуулах хэрэгтэй:*
- (а) *Байгууллагын нийт мөнгөн орлого, үүнд: тухайн байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой ангиллын суурийг ашиглан нийт мөнгөн орлогын дэд ангиллыг тусад нь харуулах;*
  - (б) *Байгууллагын нийт мөнгөн зарлага, үүнд: тухайн байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой ангиллын суурийг ашиглан нийт мөнгөн зарлагын дэд ангиллыг тусад нь харуулах;*
  - (в) *Байгууллагын мөнгөн хөрөнгийн эхний ба эцсийн үлдэгдэл.*
- 1.3.13 *Нийт мөнгөн орлого ба нийт мөнгөн зарлага, түүнчлэн мөнгөн орлого, зарлагын дэд ангилал тус бүрийн мөнгөн орлого, зарлагыг нийт дүнгээр тайлагнах хэрэгтэй, харин дараах тохиолдолд мөнгөн орлого, зарлагыг цэвэр дүнгээр тайлагнаж болно:*
- (а) *Бусад талуудын өмнөөс байгууллагын туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээнээс тэдгээр нь үүссэн бөгөөд мөнгөн орлого, зарлагын тайланд тэдгээрийг хүлээн зөвшөөрдөг; эсвэл*
  - (б) *Тэдгээр нь хурдан эргэлттэй, өндөр дүнтэй, дуусгавар болох богино хугацаатай зүйлсэд хамаардаг.*
- 1.3.14 *Мөрийн зүйлс, гарчиг, дэд дүнгүүдийн толилуулга нь тухайн байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдлийг үнэн зөв толилуулахад шаардлагатай тохиолдолд тэдгээрийг мөнгөн орлого, зарлагын тайланд толилуулах хэрэгтэй.*
- 1.3.15 Энэ Стандарт нь тухайн байгууллагын мөнгөний эхний ба эцсийн үлдэгдэл, тайлант үеийн турш дахь нийт мөнгөн орлого ба нийт мөнгөн зарлага,



тэдгээрийн гол дэд ангиллуудыг харуулсан мөнгөн орлого, зарлагын тайлан толилуулахыг бүх байгууллагуудаас шаарддаг. Энэ нь байгууллагын мөнгөний үлдэгдлүүд болон тайлант үеийн туршид тэдгээрт гарсан өөрчлөлтийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг хэрэглэгчид хандан нэвтрэх боломжтой ба ойлгомжтой хэлбэрээр санхүүгийн тайланд тусгасан эсэхийг ханган магадлалдаг.

- 1.3.16 Байгууллагын мөнгөний үлдэгдэл, түүнчлэн мөнгө нь татвар, торгууль, хураамж, зээллэгээс үүссэн эсэх ба түүнийг үйл ажиллагааны зардал, капитал хөрөнгийн худалдан авалт эсвэл өрийн эргэлтээс гаргалтанд зориулан зарцуулсан эсэх гэх мэт асуудлуудын талаархи мэдээллийн тодруулга нь санхүүгийн тайлагналын ил тод ба хариуцлагатай байдлыг сайжруулна. Эдгээр тодруулгууд нь байгууллагын мөнгөний одоогийн нөөц, ирээдүйн мөнгөн орлогын гүйлгээний магадлалт эх үүсвэр болон тогтвортой байдлын талаар илүү их мэдээлэл бүхий шинжилгээ, үнэлгээ хийхэд мөн туслалцаа үзүүлдэг.

### **Ангилал**

- 1.3.17 1.3.12 ба 1.3.14-р параграфуудын дагуу толилуулах нийт мөнгөн орлого, зарлагын дэд ангиллууд (буюу ангиуд) нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал юм. Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурьт санхүүгийн тайлагналын зорилт ба чанарын шинжүүдийн хүрээнд ийм шүүн тунгаалтыг хийнэ. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлд тусган оруулсан мэдээллийн чанарын шинжүүдийг энэ Стандартын Хавсралт 4-д товчоолон харуулсан. Мөнгөн орлогыг тухайлбал, дараах зүйлсээс үүссэн гэдгээр тусдаа тодорхойлохын тулд нийт мөнгөн орлогыг ангилж болно. Үүнд: татвар буюу төсвийн хуваарилалт; буцалтгүй тусламж ба хандив; зээл; үндсэн хөрөнгийн данснаас хасалтын орлого; үйлчилгээ үзүүлэх ба худалдаа эрхлэх бусад байнгын үйл ажиллагаа. Мөнгөн зарлагыг тухайлбал, дараах зүйлстэй холбоотой гэдгээр тусдаа тодорхойлохын тулд нийт мөнгөн зарлагыг ангилж болно: үйлчилгээ үзүүлэх байнгын үйл ажиллагаа, үүн дотроо иргэд, бусад засгийн газар буюу байгууллагуудад олгох шилжүүлэг; өр бууруулах хөтөлбөр; үндсэн хөрөнгийн худалдан авалт; аливаа худалдааны үйл ажиллагаа. Толилуулгыг өөр хувилбараар бас хийх боломжтой юм. Жишээлбэл; нийт мөнгөн орлогыг тэдгээрийн эх үүсвэрийг харгалзсанаар ангилж болох ба мөнгөн зарлагыг түүний төлбөрийн шинж төрөл, тухайн байгууллагын хүрээн дэх чиг үүрэг эсвэл хөтөлбөрийн аль тохиромжтойг харгалзан дэд ангилал үүсгэж болно.
- 1.3.18 Тайлант үеийн туршид хүлээн авсан гадаадын болон бусад тусламж, тайлангийн өдрөөр зарцуулаагүй байгаа гадаад тусламжийн үлдэгдэл ба тухайн байгууллагад бэлэн боломжтой байгаа бусад тусламжийн талаархи зарим мэдээллийн тодруулга хийхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн. Хөгжиж буй эдийн засгийн орчин дахь улсын секторын тайлагнагч олон байгууллагуудын хувьд мөнгөн хэлбэрээр хүлээн авсан гадаадын болон бусад тусламжийн дүн, тэрхүү тусламжийн ашиглан зарцуулалтыг тодорхойлох мөнгөн орлого, зарлагын ангилал нь

хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгод хамааралтай байх магадлалтай юм.

### **Мөрийн зүйлс, гарчиг, дэд дүн**

1.3.19 Дээрх 1.3.14-р параграфын шаардлагуудын дагуу, дэд ангилал тус бүрийн хүрээнд аль мөрийн зүйлс, гарчиг, дэд дүнг толилуулах хэрэгтэй эсэхийг тодорхойлоход харгалзах хүчин зүйлсэд дараах зүйлс хамаарна: энэ Стандартын бусад хэсгүүдийн шаардлагууд; хэрэглэгчдэд зориулсан тодруулгын магадлалт материаллаг байдлын үнэлгээ; шаардлагатай тайлбар ба тодруулгыг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусгах хэмжээ. Байгууллага нь санхүүгийн тайлангийн тэмдэглэлд эсвэл тухайн санхүүгийн тайланд өөрт нь тусган оруулахыг уг байгууллагад сайшаан дэмждэг, мөнгөн гүйлгээний гол нэмэлт ангиудын талаархи тодруулгыг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт заасан. Эдгээр тодруулга нь дээрх 1.3.12-р параграфын шаардлагуудыг бүх биш боловч олон тохиолдолд хангах магадлалтай юм.

### **Цэвэр дүнгээр тайлагнах**

1.3.20 Дээрх 1.3.13-р параграфт дурдсан нөхцлөөс бусад тохиолдолд мөнгөн орлого, зарлага болон үлдэгдлийг нийт дүнгээр тайлагнахыг энэ Стандартаар шаарддаг. Цэвэр дүнгээр тайлагнахыг зөвтгөн баталж болох тийм нөхцөл байдлуудыг доорх 1.3.21 ба 1.3.24-р параграфт илүү дэлгэрэнгүй авч үзсэн.

1.3.21 Засгийн газрууд, засгийн газрын хэлтэс газрууд болон засгийн газрын бусад байгууллагууд нь ажил гүйлгээнд туслалцаа үзүүлэх буюу бусдын өмнөөс агентын үүргийг өөр бусад байдлаар гүйцэтгэж болох юм. Эдгээр туслалцаа үзүүлэх болон агентын ажил гүйлгээ нь бусад байгууллагын өмнөөс орлогыг цуглуулах, шалгуур хангасан үр шим хүртэгчдэд мөнгө санг шилжүүлэх, иргэдийн өмнөөс мөнгийг хадгалах зэрэг үйл ажиллагаанаас бүрдэж болно. Ийм үйл ажиллагааны жишээнд дараах зүйлс хамаарч болох юм:

- (а) Засгийн газрын нэг түвшний өмнөөс засгийн газрын нөгөө түвшин нь татварыг цуглуулах, харин татварын орлого хуваах хэлцлийн нэг хэсэг байдлаар өөрийн хэрэгцээнд зориулж тухайн засгийн газрын цуглуулсан татвар нь үүнд хамаарахгүй;
- (б) Санхүүгийн байгууллагын зүгээс харилцах дансны хүлээн авалт ба буцаан олголт;
- (в) Үйлчлүүлэгчдийн өмнөөс хөрөнгө оруулалтын болон итгэмжлэлийн байгууллагын эзэмшиж буй мөнгө сан;
- (г) Үл хөдлөх хөрөнгийн эздийн өмнөөс цуглуулж, тэдэнд төлдөг түрээс;
- (д) Засгийн газрын хэлтэс газраас хууль тогтоомж буюу засгийн газрын бусад бүрэн эрхийн дагуу гуравдагч талд хийсэн шилжүүлэг; ба

- (е) Засгийн газрын зарлагын удирдлагын зорилгоор “нэг данс”-ны суурийн дагуу төв байгууллагаас захиран зарцуулж буй мөнгө сан (1.2.8-р параграфт дурдсан).

1.3.22 Олон тохиолдолд, бусдын агент байдлаар туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээний хувьд байгууллагын хүлээн авсан мөнгийг тухайн мөнгөний эцсийн хүлээн авагчид зориулан итгэмжлэлийн дансанд эсвэл түүний банкны дансанд шууд байршуулдаг. Ийм тохиолдолд байгууллага нь туслалцаа үзүүлсэн уг ажил гүйлгээний хувьд хүлээн авсан мөнгийг хянахгүй бөгөөд тэдгээр мөнгөн гүйлгээ нь тус байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага болон мөнгөний үлдэгдлийн нэг хэсгийг бүрдүүлэхгүй. Харин өөр зарим тохиолдолд агентын үүрэг гүйцэтгэж буй байгууллагын хянадаг банкны дансанд тухайн хүлээн авсан мөнгийг байршуулах бөгөөд тэрхүү мөнгөн орлого ба шилжүүлгийг уг байгууллагын мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнана.

1.3.23 Зарим тохиолдолд, туслалцаа үзүүлэх ажил гүйлгээнээс үүссэн ба тайлагнагч байгууллагын банкны дансаар “дамжуулах” мөнгөн гүйлгээний дүн нь тухайн байгууллагын өөрийн ажил гүйлгээтэй харьцуулахад харьцангуй их дүнтэй байж болох бөгөөд тэрхүү дүнг эцсийн хүлээн авагчид шилжүүлэхээс өмнө зөвхөн богино хугацаанд хяналт тогтоож болох юм. Бусад мөнгөн гүйлгээний хувьд тухайлбал, дараах зүйлсийн урьдчилгаа төлбөр болон буцаан төлөлтийг хийхэд ийм тохиолдол бас үүсэж болно:

- (а) Хөрөнгө оруулалтын худалдан авалт болон борлуулалт; ба
- (б) Бусад богино хугацаат зээл, жишээлбэл; гурван сар буюу түүнээс богино дуусгавар болох хугацаатай зээл.

1.3.24 Эдгээр ажил гүйлгээг нийт дүнгээр хүлээн зөвшөөрөх нь тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны үр дүн болох мөнгөн орлого ба мөнгөн зарлагын талаархи мэдээллийг хүргэн танилцуулах зарим засгийн газруудын болон засгийн газрын байгууллагуудын санхүүгийн тайлангийн чадвар боломжийг дордуулж болох юм. Иймээс дээрх 1.3.13-р параграфт дурдсан, нөхцөл байдалд мөнгөн орлого ба мөнгөн зарлагыг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах ба мөнгөн орлого, зарлагын тайланд цэвэр дүнгээр тайлагнахыг энэ Стандартаар зөвшөөрдөг.

## **Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба тайлбар тэмдэглэл**

### **Тэмдэглэлийн бүтэц**

1.3.25 ***Байгууллагын санхүүгийн тайлангийн тэмдэглэлд:***

- (а) ***Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь болон мэдэгдэхүйц ажил гүйлгээ, бусад үйл явдлын хувьд сонгосон ба мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогын талаархи мэдээллийг толилуулах хэрэгтэй; ба***

(б) *Санхүүгийн тайланд толилуулаагүй боловч байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага болон мөнгөний үлдэгдлийн үнэн зөв толилуулгад шаардлагатай нэмэлт мэдээллийг тусгах хэрэгтэй.*

1.3.26 *Санхүүгийн тайлангийн тэмдэглэлийг системчилсэн арга маягаар толилуулах хэрэгтэй. Мөнгөн орлого, зарлагын тайлан болон бусад санхүүгийн тайлангийн мөрийн зүйл нэг бүрийг тэмдэглэл дэх аливаа холбогдох мэдээлэлтэй харилцан лавлагаа үүсгэх хэрэгтэй.*

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт ба тодруулга

1.3.27 *Санхүүгийн тайланд дараах шаардлагуудыг хангасан мэдээллийг толилуулах хэрэгтэй:*

(а) *Ойлгомжтой;*

(б) *Хэрэглэгчдийн шийдвэр гаргалтын болон хариуцлагатай байдлын хэрэгцээ шаардлагад хамааралтай; ба*

(в) *Байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдэл болон санхүүгийн тайланд тодруулсан бусад мэдээллийн үнэн зөв илэрхийлэлд хүргэх, иймээс дараах шинж чанартай байх:*

(i) *Иж бүрэн;*

(ii) *Төв голч; ба*

(iii) *Материаллаг алдаагүй.*

(г) *Зэрэгцүүлэгдэх боломжтой;*

(д) *Цаг хугацаандаа байх; ба*

(е) *Шалгах боломжтой байх.*

*Санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн хязгаарлалтууд нь материаллаг байх, өртөг-өгөөжийн шалгуурыг хангах, дээрх (а)-гаас (е)-д дурдсан чанарын шинжүүдийн зохих тэнцвэрийг хангах явдал юм.*

1.3.28 Санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн чанар нь хэрэглэгчдэд уг тайлангийн үзүүлэх ач холбогдлыг тодорхойлдог. Санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн чанарын шинжүүд болон мэдээлэлд хамаарах нийтлэг хязгаарлалтуудыг 1.3.27-р параграфт тодорхойлсон. Санхүүгийн тайлан нь 1.3.27(а)-гаас 1.3.27(е) параграфт дурдсан, чанарын шинжүүдийг биелүүлэх ба санхүүгийн тайланд тусгасан мэдээлэлд тавигдах хязгаарлалтыг хангах тийм мэдээллийг бүрдүүлдэг гэдгийг ханган магадлах нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулахыг энэ параграфтаар шаардсан байдаг. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлд тусгасан мэдээллийн чанарын шинжүүд болон мэдээлэлд тавигдах хязгаарлалтуудыг энэ Стандартын Хавсралт 4-д товчоолон харуулсан.

Тайлант үеийн туршид бүрэн гүйцэд ба үнэн зөв нягтлан бодох бүртгэл хөтлөх нь санхүүгийн тайланг цаг хугацаанд нь бэлтгэхэд чухал ач холбогдолтой байдаг.

- 1.3.29 ***Санхүүгийн тайлангийн талаархи зохих ойлголтонд зайлшгүй шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого нэг бүрийг, үүн дотроо энэ Стандартын аливаа шилжилтийн нөхцлүүдийг уг байгууллага даган мөрдсөн хэмжээг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого хэсэгт тайлбарлах хэрэгтэй.***
- 1.3.30 ***Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга эсвэл тэмдэглэл буюу тайлбар материал оруулах замаар тухайн тохиромжгүй нягтлан бодох бүртгэлийн бодлогыг засаж залруулж чадахгүй юм.***
- 1.3.31 Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогыг тодруулах хэрэгтэй эсэхийг шийдвэрлэхдээ, удирдлага нь тухайн тайлагнасан мөнгөн орлого, зарлага болон мөнгөний үлдэгдэлд тэдгээр ажил гүйлгээ, үйл явдлуудыг тусгасан арга замыг ойлгоход тэрхүү тодруулга хэрэглэгчдэд туслах эсэхийг харгалзан үзнэ. Хэдийгээр тайлант болон өмнөх үеүдэд харуулсан дүнгүүд нь материаллаг бус боловч нягтлан бодох бүртгэлийн бодлого нь чухал ач холбогдолтой байж болно. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тайлбар тэмдэглэлийг агуулсан байна гэдгийг энэ Стандартын 1.3.4-р параграфт заасан. Иймээс дээрх 1.3.29-р параграфын шаардлагуудыг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд бас мөрдөнө.
- 1.3.32 ***Байгууллага нь энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн аливаа тодруулгыг өөрийн санхүүгийн тайланд тусган оруулах сонголт хийсэн тохиолдолд тэдгээр тодруулга нь дээрх 1.3.27-р параграфын шаардлагуудтай нийцсэн байвал зохино.***
- 1.3.33 Нэмэлт мэдээллийн тодруулгыг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусгахыг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн. Ийм тодруулгыг хийсэн тохиолдолд тэдгээр нь ойлгомжтой бөгөөд санхүүгийн мэдээллийн бусад чанарын шинжүүдийг хангасан байх шаардлагатай юм.

## **1.4 Ерөнхий асуудлууд**

### **Тайлант үе**

- 1.4.1 ***Нийтлэг зорилготой санхүүгийн тайланг наад зах нь жил бүр толилуулах хэрэгтэй. Байгууллагын тайлангийн өдөр өөрчлөгдсөн ба жилийн санхүүгийн тайланг нэг жилээс урт эсвэл богино хугацаагаар толилуулсан хэвийн бус нөхцөл байдалд байгууллага нь тухайн санхүүгийн тайлангийн хамрах тайлант үеэс гадна дараах зүйлсийг тодруулах ёстой:***

**(а) Нэг жилээс өөр хугацааг ашигласан шалтгаан (шалтгаанууд); ба**

**(б) Зэрэгцүүлэгдэх дүнгүүд нь бүхэлдээ зэрэгцүүлэгдэх боломжгүй болсон тухай.**

1.4.2 Тайлангийн өдөр гэдэг нь тухайн санхүүгийн тайлангийн хамаарах тайлант үеийн сүүлчийн өдөр юм. Онцгой нөхцөл байдалд, байгууллага нь тухайлбал, тайлагналын циклийг төсөвлөлтийн циклтэй илүү нийцүүлэхийн тулд өөрийн тайлангийн өдрийг өөрчлөхөөр шийдвэрлэж, эсвэл түүнээс ингэж өөрчлөхийг шаардаж болно. Ийм тохиолдолд тайлангийн өдрийн өөрчлөлтийн шалтгааныг тодруулах ба хэрэглэгчид нь тухайн тайлант үеийн хувьд харуулсан дүнгүүд, түүнчлэн зэрэгцүүлэгдэх дүнгүүд нь зэрэгцүүлэгдэх боломжгүй болсон гэдгийг мэдэж байх нь чухал ач холбогдолтой юм.

1.4.3 Ерөнхийдөө, нэг жилийн хугацаанд хамаарах санхүүгийн тайланг тууштай бэлтгэж, толилуулдаг. Гэвч практик шалтгааны улмаас зарим байгууллага нь өөр, тухайлбал; 52 долоо хоногийн хугацаагаар тайлагнахыг илүүд үздэг. Ингэж толилуулсан санхүүгийн тайлан нь нэг жилээр толилуулсан санхүүгийн тайлангаас материаллаг зөрүүтэй байх магадлал багатай учраас энэ Стандарт нь ийм практикыг хориглодоггүй.

### **Цаг хугацаандаа байх**

1.4.4 Тайлангийн өдрөөс хойшхи ул үндэслэлтэй хугацааны дотор санхүүгийн тайланг хэрэглэгчдэд хүргэн танилцуулахгүй бол түүний ач холбогдолтой байдал буурдаг. Хэдийгээр гурван сараас илүүгүй хугацааг хүчтэй дэмждэг боловч байгууллага нь тухайн тайлангийн өдрөөс хойш 6 сарын дотор өөрийн санхүүгийн тайланг гарган танилцуулах байр суурьтай байвал зохино. Байгууллагын үйл ажиллагааны нарийн цогц байдал гэх мэт байнгын хүчин зүйлс нь санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гарган тайлагнаж чадахгүй байх хангалттай зохих шалтгаан биш юм. Илүү тусгайлсан эцсийн хугацааг олон улс оронд хууль тогтоомж болон зохицуулалтанд заасан байдаг.

### **Зөвшөөрсөн өдөр**

1.4.5 ***Байгууллага нь санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдөр болон уг зөвшөөрлийг хэн өгсөн талаар тодруулга хийнэ. Хэрэв өөр нэг этгээд нь санхүүгийн тайланг нийтэд гаргасны дараа түүнд өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй бол уг байгууллага нь энэ тухай тодруулга хийнэ.***

1.4.6 Нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдөр нь санхүүгийн тайланг нийтэд гаргахын тулд эцэслэн дуусгах бүрэн эрх бүхий хувь хүн буюу байгууллагаас тухайн санхүүгийн тайлангийн хувьд зөвшөөрөл авсан өдөр юм. Санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрөөс хойшхи үйл явдлыг уг санхүүгийн тайланд тусгадаггүй тул тэрхүү өдрийг мэдэж байх нь хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг. Санхүүгийн тайланг нийтэд гаргасны

дараа аливаа нэг этгээд буюу байгууллага нь түүнд нэмэлт өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй байх цөөн ховор тохиолдлыг хэрэглэгч нар мэдэж байх нь мөн чухал ач холбогдолтой юм. Санхүүгийн тайланг нийтэд гаргасны дараа түүнд нэмэлт өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй байж болох хувь хүн буюу этгээдийн жишээнд Сайд нар, тухайн байгууллага нэг хэсэг нь болдог засгийн газар, Улсын Их Хурал, иргэдийн төлөөлөгчдийн хурал хамаарна. Хэрэв өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлт оруулсан санхүүгийн тайлан нь шинэ цогц санхүүгийн тайлан болно.

## **Байгууллагын тухай мэдээлэл**

**1.4.7 Санхүүгийн тайлангийн хамт хэвлэн нийтэлсэн мэдээллийн аль нэг хэсэгт толилуулаагүй бол байгууллага нь дараах зүйлсийг толилуулна:**

- (a) **Байгууллагын байнга оршин суух газар ба хуулийн хэлбэр, түүний үйл ажиллагаагаа явуулдаг улс орон;**
- (б) **Байгууллагын үйл ажиллагааны шинж төрөл ба түүний үндсэн үйл ажиллагаануудын талаархи тайлбар тодорхойлолт;**
- (в) **Хэрэв байдаг бол тухайн байгууллагын үйл ажиллагааг удирдан зохицуулах холбогдох хууль тогтоомжийн талаархи лавлагаа; ба**
- (г) **Санхүүгийн тайланд толилуулдаг томоохон байгууллагууд буюу засгийн газрын секторууд, түүнчлэн тухайн тайлагнагч байгууллагыг бүрдүүлдэг бөгөөд өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайланд толилуулсан томоохон байгууллагууд буюу секторуудын өөрчлөлтүүд.**

1.4.8 Санхүүгийн тайланг нэг байгууллага эсвэл засгийн газрын хэлтэс газар, агентлаг, хөтөлбөр зэрэг захиргааны нэгжийн хувьд; нийт засгийн газрын хувьд; байгууллагуудын бүлэг эсвэл төсвийн сектор, засгийн газрын үндсэн сектор, засгийн газрын бусад секторыг тусган илэрхийлдэг гэх мэт тодорхойлж болох үйл ажиллагаануудын хувьд бэлтгэж болно. 1.4.7-р параграфтаар шаардсан мэдээллийн тодруулга нь тухайн байгууллагын үйл ажиллагааны шинж төрлийг тодорхойлох, түүний үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн болон зохицуулалтын орчны талаар ойлголттой болох боломжийг хэрэглэгчдэд олгодог. Энэ нь уг тайлагнагч байгууллагыг бүрдүүлдэг томоохон байгууллагууд буюу секторууд, түүнчлэн сүүлийн тайлангийн өдрөөс хойш тэдгээрт орсон өөрчлөлтийг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог. Мөн энэ нь хариуцлагын зорилгын хувьд зайлшгүй шаардлагатай бөгөөд тухайн байгууллагын санхүүгийн тайланг ойлгож, үнэлэхэд хэрэглэгчдэд тусална.

## **Мөнгөний үлдэгдэлд болон зээл авахад тавигдах хязгаарлалт**

**1.4.9 Байгууллага нь дараах зүйлсийн шинж төрөл ба дүнг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд холбогдох тайлбарын хамтаар тодруулна:**

- (а) *Тухайн байгууллага ашиглах боломжгүй мэдэгдэхүйц дүнтэй мөнгөний үлдэгдэл;*
- (б) *Гаднын хязгаарлалт тавигдсан мэдэгдэхүйц дүнтэй мөнгөний үлдэгдэл; ба*
- (в) *Ирээдүйн үйл ажиллагаанд болон капиталын хариуцлагыг биелүүлэхэд ашиглагдах боломжтой боловч ашиглан зарцуулаагүй байгаа зээлийн эх үүсвэрийн дүн, мөн тэдгээр эх үүсвэрийн ашиглалтанд тавигдах аливаа хязгаарлалтуудыг илэрхийлэх.*

1.4.10 Байгууллагын эзэмшиж буй мөнгөний үлдэгдэл нь тухайн байгууллагад ашиглагдах боломжгүй нөхцөл байдлууд байдаг. Жишээлбэл; хяналтанд буй байгууллага нь валютын зохицуулалт буюу эрх зүйн бусад хязгаарлалтыг мөрддөг улс оронд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд түүний мөнгөний үлдэгдлийг тухайн хяналт тавигч байгууллага болон хяналтанд буй бусад байгууллагууд нь ерөнхий хэрэгцээнд зориулан ашиглан зарцуулах боломжгүй байдаг.

1.4.11 Байгууллагын хянаж буй мөнгөний үлдэгдэл нь түүний ашиглалтын зориулалт буюу хугацааг заасан хязгаарлалтанд захирагддаг байж болно. Байгууллага нь тусгай зорилгод ашиглах ёстой буцалтгүй тусламж буюу хандив хүлээн авсан тохиолдолд ийм нөхцөл байдал байнга үүсдэг. Байгууллага нь агент болохын хувьд түүний бүрэн эрхийн хүрээнд бусад талуудын өмнөөс цуглуулсан боловч тэдгээр талуудад хараахан шилжүүлээгүй байгаа мөнгийг тухайн тайлангийн өдрөөр өөрийн банкны дансандаа байршуулан эзэмшиж байгаа тохиолдолд ийм нөхцөл байдал бас үүсэж болох юм. Хэдийгээр байгууллага нь тэдгээр мөнгөний үлдэгдлийг хянаж, өөрийн мөнгөний үлдэгдэл байдлаар тайлагнасан боловч ийм зүйлсийн дүнгийн талаархи тусдаа тодруулга нь хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг.

1.4.12 Зарцуулаагүй зээлийн хэрэгсэл нь тухайн байгууллагын мөнгөний боломжит эх үүсвэрийг илэрхийлнэ. Эдгээр хэрэгслүүдийн дүнгийн гол төрлөөр харуулсан тодруулга нь ийм мөнгөний бэлэн боломжтой байдал ба тухайн тайлант үеийн туршид түүнээс байгууллагын ашиглан зарцуулсан хэмжээг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог.

### **Толилуулгын тууштай байдал**

1.4.13 *Доор дурдснаас бусад тохиолдолд, санхүүгийн тайлан дахь зүйлсийн толилуулга ба ангиллыг нэг тайлант үеэс дараагийн тайлант үед хэвээр хадгална:*

- (а) *Байгууллагын үйл ажиллагааны шинж төрлийн мэдэгдэхүйц өөрчлөлт эсвэл түүний санхүүгийн тайлангийн нягтлах шалгалтын дараа, 1.3.27-р параграфт заасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт ба мөрдөлтийн шалгуурыг харгалзан үзэхэд өөр толилуулга буюу тодруулга илүү тохиромжтой гэдэг нь илт тодорхой болсон байх; эсвэл*



**(б) Энэ Стандартад ирээдүйд оруулах нэмэлт өөрчлөлт нь толилуулгыг өөрчлөхийг шаардах.**

- 1.4.14 Үйлчилгээ үзүүлэх хэлцлийн томоохон өөрчлөлт, засгийн газрын шинэ байгууллага үүсгэн байгуулалт эсвэл одоо байгаа гол байгууллагыг татан буулгалт, томоохон худалдан авалт буюу данснаас хасалт, тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгын нягтлах шалгалт нь мөнгөн орлого, зарлагын тайлан буюу бие даасан бусад санхүүгийн тайланг өөрөөр толилуулах хэрэгтэй гэдгийг илэрхийлж болох юм. Жишээлбэл; засгийн газар нь өөрийн хяналтанд буй хамгийн том байгууллагуудын нэг болох хадгаламжийн банкыг данснаас хассан ба үлдсэн бусад байгууллагууд нь үндсэндээ захиргааны болон бодлогын зөвлөх үйлчилгээг эрхлэн явуулж болох юм. Энэ тохиолдолд санхүүгийн байгууллага гэсэн уг засгийн газрын үндсэн үйл ажиллагаанд үндэслэсэн санхүүгийн тайлангийн толилуулга нь хамааралтай байх магадлал багатай болно.
- 1.4.15 Уг өөрчилсөн бүтцийг цааш үргэлжлүүлэх магадлалтай, эсвэл өөр хувилбар толилуулга нь үнэн зөв илэрхийлэх ба тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд илүү их хамааралтай мэдээллээр хангадаг зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь өөрийн санхүүгийн тайлангийн толилуулгыг өөрчилвөл зохино. Толилуулгад ийм өөрчлөлт хийсэн тохиолдолд байгууллага нь өөрийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг 1.4.19-р параграфын дагуу дахин ангилна. Байгууллага нь энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартыг мөрддөг бол үндэсний шаардлагуудыг даган мөрдөхийн тулд хийх толилуулгын өөрчлөлт нь энэ Стандартын шаардлагуудтай нийцэх зөвхөн тийм тохиолдолд толилуулгын өөрчлөлт хийхийг түүнд зөвшөөрнө.

**Зэрэгцүүлэгдэх мэдээлэл**

- 1.4.16 **Энэ Стандартын нөхцөл заалт өөрөөр шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага нь энэхүү Стандартыг анх удаа мөрдөж буй тайлант үеийн санхүүгийн тайлангаас бусад, тэдгээр санхүүгийн тайланд тусгахыг тус Стандартаар шаардсан бүх тоон мэдээллийн хувьд харгалзах өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах хэрэгтэй. Хэрэв тухайн тайлант үеийн санхүүгийн тайланг ойлгоход хамааралтай бол хүүрнэсэн ба тайлбарласан мэдээллийн хувьд мөн зэрэгцүүлэгдэх мэдээллийг тусган оруулах хэрэгтэй.**
- 1.4.17 Энэ Стандарт нь мөнгөн орлого, зарлагын тайланг толилуулахыг шаарддаг бөгөөд тухайн тайланд болон түүний тэмдэглэлд тусган оруулах хэрэгтэй зарим тодруулгыг тусгайлан заасан. Нэмэлт санхүүгийн тайлан бэлтгэхийг энэ Стандартаар хориглодоггүй. Зарим нэмэлт тодруулга хийхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн байдаг. Мөнгөн орлого, зарлагын тайлангаас гадна санхүүгийн тайланг бэлтгэсэн буюу энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн тодруулгыг хийсэн

тохиолдолд зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулга хийхийг мөн сайшаан дэмжинэ.

- 1.4.18 Зарим тохиолдолд өмнөх тайлант үеийн (үеүдийн) санхүүгийн тайланд тусгасан, хүүрнэсэн мэдээлэл нь тухайн тайлант үед мөн хамааралтай хэвээр байдаг. Жишээлбэл; өмнөх тайлант үеийн эцсээр үр дагавар нь тодорхойгүй буюу хараахан шийдэгдээгүй байсан хуулийн зарга маргааны талаархи дэлгэрэнгүй мэдээллийг байгууллага нь тухайн тайлант үед тусган тодруулдаг. Өмнөх тайлант үеийн эцэст байсан тодорхойгүй зүйлсийн талаархи мэдээллийн тодруулга ба уг тодорхойгүй байдлыг шийдвэрлэхийн тулд тухайн тайлант үеийн туршид авсан арга хэмжээний талаархи мэдээллийн тодруулга нь хэрэглэгчдэд ач холбогдолтой байж болно.
- 1.4.19 ***Санхүүгийн тайланд тодруулах шаардлагатай зүйлсийн толилуулга буюу ангилалд нэмэлт өөрчлөлт оруулсан бол тухайн тайлант үетэй зэрэгцүүлэгдэх боломжтой байдлыг хангахын тулд дахин ангилал хийх практик боломжгүй байхаас бусад тохиолдолд зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг дахин ангилах бөгөөд ийм аливаа дахин ангиллын шинж төрөл, дүн, шалтгааныг тодруулах хэрэгтэй. Зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг дахин ангилах практик боломжгүй тохиолдолд байгууллага нь дүнгүүдийг дахин ангилаагүй шалтгаан, хэрэв дүнгүүдийг дахин ангилсан бол хийгдэх байсан өөрчлөлтийн шинж төрлийг тодруулах хэрэгтэй.***
- 1.4.20 Тайлант үетэй зэрэгцүүлэгдэх боломжтой болохын тулд зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин ангилах практик боломжгүй тохиолдолд ийм нөхцөл байдал үүсэж болох юм. Жишээлбэл; дахин ангилал хийх боломжтой байдлаар өмнөх тайлант үеүдийн мэдээг цуглуулан бүрдүүлээгүй ба уг мэдээллийг дахин бүрдүүлэх практик боломжгүй байж болох юм. Ийм тохиолдолд зэрэгцүүлэгдэх дүнгүүдэд хийх байсан залруулгын шинж төрлийг тодруулна.

### **Санхүүгийн тайлангийн ялган тодорхойлолт**

- 1.4.21 ***Санхүүгийн тайланг ойлгомжтой байдлаар ялган тодорхойлох ба хэвлэн нийтэлж буй баримт бичиг дэх бусад мэдээллээс ялган илэрхийлэх хэрэгтэй.***
- 1.4.22 Энэ Стандартыг зөвхөн санхүүгийн тайланд мөрдөх бөгөөд жилийн тайлан илтгэл буюу өөр бусад баримт бичигт толилуулж буй бусад мэдээлэлд мөрдөхгүй. Иймээс хэрэглэгчид нь энэ Стандартыг ашиглан бэлтгэсэн мэдээллийг тэдэнд ач холбогдолтой байж болох боловч стандартын шаардлагуудад хамаарахгүй бусад мэдээллээс ялган зааглаж чадахаар байх нь чухал ач холбогдолтой юм.
- 1.4.23 ***Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг ойлгомжтой байдлаар ялган тодорхойлох хэрэгтэй. Түүнчлэн, дараах мэдээллийг тов тодорхой харуулах ба толилуулж буй мэдээллийг***

**зөв ойлгоход зайлшгүй шаардлагатай тохиолдолд давтан илэрхийлнэ:**

- (а) **Тайлагнагч байгууллагын нэр буюу ялган тодорхойлох бусад илэрхийлэлт;**
- (б) **Бие даасан байгууллагын эсвэл эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайлан эсэх;**
- (в) **Санхүүгийн тайланд хамаарах тайлангийн өдөр буюу хамрагдах тайлант үе, энэ нь санхүүгийн тайлангийн тухайн бүрэлдэхүүн хэсгийн хувьд тохиромжтой эсэх;**
- (г) **Толилуулгын валют; ба**
- (д) **Санхүүгийн тайланд дүнг толилуулахдаа хэрэглэсэн бүхэлчлэлийн түвшин.**

1.4.24 Санхүүгийн тайлангийн хуудас бүрийн хувьд хуудасны нэр гарчиг болон баганын толгойн хураангуйлсан нэрийг бичсэнээр 1.4.23-р параграфт заасан шаардлагуудыг үндсэндээ ханган биелүүлнэ. Ийм мэдээллийг толилуулах хамгийн сайн арга замыг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Жишээлбэл; санхүүгийн тайланг цахим хэлбэрээр толилуулах тохиолдолд тусдаа хуудсуудыг байнга ашиглах шаардлагагүй байж болно. Тухайн тусгасан мэдээллийн ойлгомжтой байдлыг хангахын тулд 1.4.23-р параграфт заасан зүйлсийг байнга толилуулна.

1.4.25 Толилуулгын валютын мянгачилсан эсвэл саячилсан дүнгээр мэдээллийг толилуулснаар санхүүгийн тайланг ойлгоход ихэвчлэн илүү хялбар болгодог. Толилуулга дахь бүхэлчлэлийн түвшинг заасан бөгөөд материаллаг мэдээллийг орхигдуулаагүй тохиолдолд ингэж бүхэлчлэхийг зөвшөөрнө.

## **1.5 Алдааны засварлалт**

1.5.1 **Санхүүгийн тайланд тайлагнасан мөнгөний үлдэгдэлтэй холбоотой алдаа гарсан тохиолдолд тухайн тайлант үеийн эхэн дэх мөнгийг залруулснаар уг өмнөх тайлант үеүдэд хамаарах алдааны дүнг тайлагнана. Зэрэгцүүлэгдэх мэдээллийг практик боломжгүй байхаас бусад тохиолдолд дахин илэрхийлнэ.**

1.5.2 **Байгууллага нь санхүүгийн тайлангийн тэмдэглэлд дараах зүйлсийг тодруулна:**

- (а) **Өмнөх тайлант үетэй холбоотой алдааны шинж төрөл;**
- (б) **Засварлалтын дүн; ба**
- (в) **Зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин илэрхийлсэн эсвэл ингэж дахин илэрхийлэх практик боломжгүй тухай.**

- 1.5.3 Тайлант үед илрүүлсэн тухайн тайлант үеийн боломжит алдааг уг санхүүгийн тайланг гаргахаар зөвшөөрөхөөс өмнө засварладаг. Нэг буюу хэд хэдэн өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайланг бэлтгэхэд гарсан алдааг тухайн тайлант үед илрүүлж болох юм. Математик үйлдлийн алдаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхөд гаргасан алдаа, баримт материалын буруу тайлбарлалт, хайнга хандалт, зальт ажиллагааны улмаас алдаа гарч болох юм. Өмнөх тайлант үеийн хувьд алдаа илрүүлсэн тохиолдолд уг өмнөх тайлант үеийн алдааг болон санхүүгийн тайланг, үүн дотроо өмнөх тайлант үеүдийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг засварлахын тулд мөнгөний эхний үлдэгдлийг залруулах бөгөөд уг алдаа гаргасан тайлант үед түүнийг засварласан мэтээр толилуулна. Алдаа ба түүний залруулгын талаархи тайлбарыг тэмдэглэлд тусгана.
- 1.5.4 Зэрэгцүүлэгдэх мэдээллийн дахин илэрхийлэлт нь удирдах байгууллагаас баталсан, эсвэл зохицуулалтын эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн буюу тушааж танилцуулсан санхүүгийн тайланд заавал нэмэлт өөрчлөлт оруулах албагүй юм. Гэвч ийм санхүүгийн тайланд нэмэлт өөрчлөлт оруулахыг үндэсний хууль тогтоомжоор шаардаж болох юм.
- 1.5.5 Энэ Стандарт нь мөнгөн орлого, зарлагын тайлан толилуулахыг шаардах бөгөөд бусад санхүүгийн тайлан толилуулахыг хориглодоггүй. Мөнгөн орлого, зарлагын тайлангаас гадна санхүүгийн тайланг толилуулах тохиолдолд алдааны засварлалтын талаархи 1.5.1 ба 1.5.2-р параграфын шаардлагуудыг тэдгээр тайланд бас мөрдөнө.

## 1.6 Гадаад валют

### Тодорхойлолт

- 1.6.1 *Дараах нэр томъёог энэ Стандартад доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:*

*Хаалтын ханш гэдэг нь тайлангийн өдрийн спот ханш юм.*

*Ханшийн зөрүү гэдэг нь ижил тооны гадаад валютыг толилуулгын валютад өөр өөр ханшаар хөрвүүлснээс үүссэн зөрүү юм.*

*Валютын ханш гэдэг нь хоёр валютын хоорондох солилцооны харьцаа юм.*

*Гадаад валют гэдэг нь байгууллагын толилуулгын валютаас өөр валют юм.*

*Толилуулгын валют гэдэг нь тухайн санхүүгийн тайланг толилуулахад ашигладаг валют юм.*

**Гадаад валютаарх мөнгөн орлого, зарлага, үлдэгдлийн бүртгэлийн арга**

- 1.6.2 *Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн орлого, зарлагыг уг орлого, зарлага гарсан өдрийн толилуулгын валют*

***болон гадаад валютын хоорондох ханшаар тэрхүү гадаад валютын дүнг үржүүлж, тухайн байгууллагын толилуулгын валютаар бүртгэнэ.***

- 1.6.3 ***Гадаад валютаар эзэмшиж буй мөнгөний үлдэгдлийг хаалтын ханшийг ашиглан тайлагнана.***
- 1.6.4 ***Хяналтанд буй гадаад дахь байгууллагын мөнгөн орлого ба мөнгөн зарлагыг уг орлого, зарлага гарсан өдрийн толилуулгын валют болон гадаад валютын хоорондох ханшаар хөрвүүлнэ.***
- 1.6.5 ***Байгууллага нь тухайн тайлант үеийн мөнгөний эхний ба эцсийн үлдэгдлийн хоорондох тохируулгын зүйлс байдлаар тусган оруулсан ханшийн зөрүүгийн дүнг тодруулна.***
- 1.6.6 ***Толилуулгын валют нь тухайн байгууллагын оршин суугаа улсын валютаас өөр бол ийм өөр валют ашиглаж буй шалтгааныг тодруулна. Толилуулгын валютын аливаа өөрчлөлтийн шалтгааныг бас тодруулна.***
- 1.6.7 Засгийн газрууд болон засгийн газрын байгууллагууд нь гадаад валютын зээл авах, гадаадын болон бусад тусламжийг гадаад валют хэлбэрээр хүлээн авах, эсвэл худалдан авалтын үнийг гадаад валютаар илэрхийлсэн бараа, үйлчилгээ худалдан авах гэх мэт гадаад валютын ажил гүйлгээ хийж болох юм. Тэд мөн гадаад үйл ажиллагаатай байж болох бөгөөд гадаад үйл ажиллагаандаа мөнгө шилжүүлж эсвэл түүнээс хүлээн авч болно. Гадаад валютаарх ажил гүйлгээ болон гадаад үйл ажиллагааг санхүүгийн тайланд тусгахын тулд тайлагнагч байгууллага нь өөрийн санхүүгийн тайланг толилуулдаг валютаар уг мөнгөн орлого, зарлага болон үлдэгдлийг илэрхийлэх ёстой.
- 1.6.8 Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй олз, гарз нь мөнгөн орлого, зарлага биш юм. Гэвч тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх мөнгөний үлдэгдлийг тохируулахын тулд гадаад валютаар эзэмшиж буй мөнгөнд валютын ханшийн өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөөг мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнана. Энэхүү дүнг мөнгөн орлого, зарлагаас тусдаа толилуулах бөгөөд хэрэв тэдгээр мөнгөн орлого, зарлага болон үлдэгдлийг тайлант үеийн эцсийн ханшаар тайлагнасан бол үүсэх аливаа зөрүүг үүнд хамруулна.

## **1.7 Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга**

### **Тодорхойлолт**

- 1.7.1 ***Дараах нэр томъёог энэ Стандартад доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:***

***Нягтлан бодох бүртгэлийн суурь гэдэг нь аккруэл суурьт УСНББОУС болон мөнгөн суурьт УСНББОУС-д тодорхойлсон нягтлан бодох бүртгэлийн аккруэл буюу мөнгөн суурь юм.***

**Жилийн төсөв гэдэг нь нэг жилийн хувьд батлагдсан төсөв юм. Тухайн төсвийн жилээс хойшхи тайлант үеүдийн хувьд хэвлэн нийтэлсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл нь үүнд хамаарахгүй.**

**Төсвийн хуваарилалт гэдэг нь хууль тогтоох буюу адилтгах эрх бүхий этгээдийн тусгайлан тодорхойлсон зорилгод зориулан мөнгө санг хуваарилахын тулд хууль тогтоогч байгууллагаас олгосон зөвшөөрөл юм.**

**Батлагдсан төсөв гэдэг нь хууль, төсвийн хуваарилалтын мэдэгдэл, засгийн газрын тогтоол болон тухайн төсвийн хугацааны урьдчилан төсөөлсөн орлого буюу мөнгөн орлоготой холбоотой бусад шийдвэрээр үүсэх зарлагын эрх юм.**

**Төсвийн суурь гэдэг нь хууль тогтоогч байгууллагаас баталсан тухайн төсөвт мөрддөг нягтлан бодох бүртгэлийн аккруэл, мөнгөн буюу бусад суурь юм.**

**Зэрэгцүүлэгдэх суурь гэдэг нь тухайн нэг байгууллагуудын хувьд уг батлагдсан төсөвтэй ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн суурь болон нэг ижил ангиллын сууриар толилуулсан гүйцэтгэлийн дүн юм.**

**Тодотгосон төсөв гэдэг нь тухайн төсвийн хугацаанд хамаарах бүх нөөц, өмнөх үеэс шилжиж ирсэн дүн, шилжүүлэг, хуваарилалт, нэмэлт төсвийн хуваарилалт болон бусад зөвшөөрөгдсөн хууль тогтоомжийн буюу адилтгах бүрэн эрхийн дагуу хийгдсэн өөрчлөлтийн хувьд тохируулга хийсэн анхны төсөв юм.**

**Олон-жилийн төсөв гэдэг нь нэгээс олон жилийн хувьд батлагдсан төсөв юм. Тухайн төсвийн хугацаанаас хойшхи тайлант үеүдийн хувьд хэвлэн нийтэлсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл нь үүнд хамаарахгүй.**

**Анхны төсөв гэдэг нь тухайн төсвийн хугацааны хувьд анх батлагдсан төсөв юм.**

## **Батлагдсан төсөв**

- 1.7.2 Энэ Стандартад тодорхойлсончлон, батлагдсан төсөв нь одоогийн төлөвлөгөө болон тухайн төсвийн хугацааны туршид урьдчилан төсөөлсөн эдийн засгийн нөхцөл байдал, хууль тогтоох эсвэл бусад холбогдох бүрэн эрх бүхий хууль тогтоогч байгууллагын баталсан зардал буюу зарлагад үндэслэн тэрхүү жилийн эсвэл олон жилийн төсвийн хугацаанд үүсэхээр хүлээгдэж буй урьдчилан төсөөлсөн орлого буюу мөнгөн орлогыг тусгадаг. Батлагдсан төсөв нь гарч тохиолдохоор заавал хүлээгдээгүй ирээдүйн үйл явдлууд болон удирдлагын боломжит үйлдлийн талаархи таамаглалд үндэслэсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл биш юм. Үүнтэй адилаар, батлагдсан төсөв нь прогноз, төсөөлөл эсвэл эдгээрийн хослол, жишээлбэл; нэг жилийн прогноз ба таван жилийн төсөөлөл хэлбэртэй байх хэтийн санхүүгийн мэдээллээс ялгаатай юм.

- 1.7.3 Зарим улс оронд, төсвийг батлах үйл явцын нэгэн хэсэг байдлаар тухайн төсвийг хуульчлан баталдаг байж болно. Өөр зарим улс оронд, төсвийг хууль болгохгүйгээр баталдаг байж болох юм. Батлах үйл явц ямар байхаас үл хамааран тухайн батлагдсан төсвийн гол шинж нь тохиролцсон ба тогтоосон зорилгод зориулан засгийн газрын төрийн сан буюу адилтгах байгууллагаас мөнгө санг татан авах эрхийг хууль тогтоогч дээд түвшний байгууллага буюу зохих эрх бүхий бусад байгууллагаас олгох явдал юм. Батлагдсан төсөв нь тусгайлан заасан зүйлсийн хувьд зарлагын эрхийг тогтоодог. Зарлагын эрхийг ерөнхийдөө хууль ёсны хязгаар гэж үздэг бөгөөд байгууллага нь энэхүү хүрээнд үйл ажиллагаагаа явуулах ёстой. Зарим улс орны хувьд, тухайн байгууллагад хариуцуулах батлагдсан төсөв нь анхны төсөв байж болно, харин өөр зарим улс оронд тодотгосон төсөв байж болох юм.
- 1.7.4 Төсвийн хугацаа эхлэхээс өмнө төсвийг батлаагүй бол анхны төсөв нь тухайн төсвийн жилд мөрдөхөөр анх баталсан төсөв байдаг.

#### **Анхны болон тодотгосон төсөв**

- 1.7.5 Анхны төсөв нь өмнөх жилүүдээс хуулийн дагуу автоматаар шилжиж ирсэн, төсвийн хуваарилалтын зарцуулагдаагүй үлдэгдлийг агуулсан байж болно. Жишээлбэл; зарим улс оронд засгийн газрын төсөвлөлтийн үйл явц нь өмнөх жилийн амлалтыг биелүүлэхийн тулд өмнөх төсвийн хуваарилалтыг автоматаар дараагийн жилд шилжүүлэхийг шаардсан хуулийн заалттай байдаг. Амлалт нь одоогийн гэрээ хэлцэлд үндэслэсэн ирээдүйн боломжит өр төлбөрийг агуулдаг. Зарим улс оронд амлалтыг үүрэг эсвэл хариуцлага гэж нэрлэдэг бөгөөд бараа, үйлчилгээг хараахан хүлээн аваагүй байх үеийн биелэгдээгүй худалдан авалтын захиалга ба гэрээ нь үүнд хамаардаг.
- 1.7.6 Анхны төсөв нь тухайлбал, дайн байлдаан буюу байгалийн гамшгаас үүдэлтэй зарлагын хэрэгцээ шаардлагуудыг зохих ёсоор хангаж чадахгүй тохиолдолд нэмэлт төсвийн хуваарилалт шаардлагатай байж болох юм. Түүнчлэн, тайлант үеийн төсөвлөсөн орлого тасалдах ба тухайн төсвийн жилийн туршид санхүүжилтийн тэргүүн ээлжийн эрхийг өөрчлөхийн тулд төсвийн бүрэлдэхүүн хооронд эсвэл төсвийн мөрийн зүйлс хооронд дотоод шилжүүлэлт хийх шаардлагатай байж болно. Иймээс төсвийн сахилга батыг хангахын тулд тухайн тайлант үед анх хуваарилсан дүнгээс уг байгууллагад буюу үйл ажиллагаанд хуваарилсан мөнгө санг буцаан багасгах шаардлагатай байж болох юм. Тодотгосон төсөв нь ийм зөвшөөрөгдсөн бүх өөрчлөлт буюу нэмэлт өөрчлөлтийг тусгасан байдаг.

#### **Гүйцэтгэлийн дүн**

- 1.7.7 Төсвийн хэрэгжилтийн үр дүн болох дүнгүүдийг илэрхийлэхийн тулд энэ Стандартад гүйцэтгэл буюу гүйцэтгэлийн дүн гэсэн нэр томъёог ашигласан. Зарим улс оронд, төсвийн төлөвлөгөөний биелэлт, төсвийн хэрэгжилт болон адилтгах нэр томъёог гүйцэтгэл буюу гүйцэтгэлийн дүн гэдэгтэй ижил утгатайгаар ашигладаг байж болох юм.

## **Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлсэн толилуулга**

1.7.8 *1.7.17-р параграфт шаардсанаас бусад тохиолдолд, батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллага нь олон нийтийн өмнө хариуцах төсвийн дүн ба гүйцэтгэлийн дүн хоорондох зэрэгцүүлэлтийг тусад нь нэмэлт санхүүгийн тайлан байдлаар эсвэл энэхүү Стандартын дагуу одоо толилуулж буй мөнгөн орлого, зарлагын тайлан дахь төсвийн нэмэлт багана хэлбэрээр толилуулна. Хууль тогтоомжийн хяналтын түвшин бүрийн хувьд төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусад нь толилуулна:*

- (a) *Анхны болон тодотгосон төсвийн дүнгүүд;*
- (б) *Зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүнгүүд; ба*
- (в) *Олон нийтийн өмнө тухайн байгууллагын хариуцдаг төсөв болон гүйцэтгэлийн дүнгийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг уг санхүүгийн тайлангийн хамтаар гаргаж, олон нийтэд танилцуулдаг бусад баримт бичигт тусган оруулдаг бөгөөд тэдгээр баримт бичигт харилцан лавлагаа үүсгэж, санхүүгийн тайлангийн тодруулгад харуулдагаас бусад тохиолдолд тэмдэглэл тодруулга хэлбэрээр хийх ийм тайлбар.*

### **Цар хүрээ**

1.7.9 Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай буюу тийм сонголт хийсэн бүх байгууллагуудад энэ Стандартыг мөрдөнө. Энэ Стандарт нь батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулахыг шаардахгүй, мөн олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй, тийм батлагдсан төсвийн талаар санхүүгийн тайлангийн тодруулгын мэдээлэл бэлтгэх буюу төсөвтэй зэрэгцүүлэхийг шаардахгүй.

1.7.10 Батлагдсан төсөв нь улсын секторын хяналтанд буй бүх үйл ажиллагааг хамрах байдлаар зарим үед зохиогдсон байдаг. Өөр зарим тохилдолд, засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын санхүүгийн тайланд тусгасан тодорхой үйл ажиллагаа, бүлэг үйл ажиллагаа буюу байгууллагуудын хувьд тусдаа батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулах шаардлагатай байж болох юм. Тухайлбал; засгийн газрын санхүүгийн тайлан нь үйл ажиллагааны хувьд хараат бус бөгөөд өөрсдийн төсвийг бэлтгэдэг тийм засгийн газрын агентлагууд буюу хөтөлбөрүүдийг агуулдаг, эсвэл нийт засгийн газрын зөвхөн үндсэн секторын хувьд төсвийг бэлтгэдэг бол ийм тохиолдол үүсэж болно. Тухайн байгууллагын хувьд батлагдсан төсөв буюу түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг олон нийтэд нээлттэй танилцуулах үедээ санхүүгийн тайлангаа толилуулдаг бүх байгууллагуудын хувьд энэ Стандартыг мөрдөнө.



### **Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт**

- 1.7.11 Анхны болон тодотгосон төсвийн дүнгүүд, түүнчлэн олон нийтэд нээлттэй танилцуулдаг төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар харуулсан гүйцэтгэлийн дүнгүүдийн санхүүгийн тайлан дахь толилуулга нь нөөцийг уг батлагдсан төсвийн дагуу олж авч, ашиглан зарцуулсан эсэхийг тодорхойлох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгосноор тухайн хариуцлагын циклийг иж бүрэн болгодог. Анхны эсвэл тодотгосон төсөв гэдгээс үл хамааран төсвийн болон гүйцэтгэлийн дүн хоорондох зөрүүг (нягтлан бодох бүртгэлд ихэвчлэн “хэлбэлзэл” гэж нэрлэдэг) иж бүрэн байдлын зорилгоор санхүүгийн тайланд мөн толилуулж болох юм.
- 1.7.12 Гүйцэтгэлийн дүн ба төсвийн дүнгийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбар нь олон нийтийн өмнө тухайн байгууллагын хариуцах уг батлагдсан төсвөөс материаллагаар гажсан шалтгааныг ойлгоход хэрэглэгчдэд тусална.
- 1.7.13 Байгууллага нь өөрийн анхны төсөв, тодотгосон төсөв эсвэл эдгээрийн аль алиныг олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай буюу ингэж танилцуулах сонголт хийж болох юм. Анхны болон тодотгосон төсвийн аль алиныг олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай тохиолдолд уг анхны төсвийн дүн ба гүйцэтгэлийн дүн хоорондох, эсвэл тодотгосон төсөв ба түүний гүйцэтгэлийн дүн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг 1.7.8(в) параграфын дагуу хийх шаардлагатай эсэх талаархи заавар удирдамжийг ихэвчлэн хууль тогтоомж, зохицуулалт буюу бусад эрх бүхий баримт бичигт заасан байдаг. Ийм аливаа заавар удирдамж байхгүй тохиолдолд жишээлбэл, анхны төсөвтэй гүйцэтгэлийг харьцуулахад голлон анхаарахын тулд тэрхүү анхны төсөв ба гүйцэтгэлийн дүн хоорондох зөрүүг, эсвэл тодотгосон төсвийн даган мөрдөлтөнд голлон анхаарахын тулд тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн дүн хоорондох зөрүүг лавлагаа болгосноор уг материаллаг зөрүүг тодорхойлж болох юм.
- 1.7.14 Тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн дүн нь олон тохиолдолд ижил байдаг. Яагаад гэвэл, төсвийн хэрэгжилтийг тайлант үеийн туршид хянан үнэлдэг бөгөөд тухайн тайлант үед өөрчлөгдөж буй нөхцөл, өөрчлөгдөж буй төлөв байдал болон туршлагыг тусгахын тулд анхны төсвийг явцын дунд хянан засварладаг. Анхны болон тодотгосон төсөв хоорондох өөрчлөлтийн шалтгааны талаархи тайлбарын хувьд тодруулга хийхийг энэ Стандартын 1.7.23-р параграфтаар шаардсан байдаг. Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллагууд нь өөрсдийн гүйцэтгэлийг тэдгээр холбогдох батлагдсан төсөвтэй харьцуулж, түүнтэй нийцсэн байдлаар олон нийтэд нээлттэй танилцуулдаг эсэхийг эдгээр тодруулга болон дээрх 1.7.8-р параграфтаар шаардсан тодруулга нь харуулна.
- 1.7.15 Тайлант үеийн турш дахь уг байгууллагын гүйцэтгэл ба ололт амжилтын талаархи санал мэдэгдэл, үүн дотроо төсвийн дүнгээс гажсан аливаа материаллаг зөрүүгийн тайлбараар хангадаг удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ, үйл ажиллагааны тойм мэдээ буюу олон нийтэд танилцуулдаг бусад тайланг ихэвчлэн тухайн санхүүгийн тайлантай хамт

гаргадаг. Энэ Стандартын 1.7.8(в) параграфт заасанчлан, гүйцэтгэлийн болон төсвийн дүнгүүдийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг тухайн санхүүгийн тайлангийн хамт гаргаж, олон нийтэд танилцуулдаг бусад тайлан буюу баримт бичигт тусган оруулдаг бөгөөд ийм тайлбарыг хийсэн тайлан буюу баримт бичгийг уг санхүүгийн тайланд тодруулдаг байхаас бусад тохиолдолд түүнийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусган харуулна.

- 1.7.16 Санхүүгийн тайланд тусган оруулсан зөвхөн зарим байгууллага буюу үйл ажиллагааны хувьд тухайн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаг тохиолдолд тэрхүү батлагдсан төсөвт тусгасан зөвхөн тэдгээр байгууллага буюу үйл ажиллагаанд 1.7.8-р параграфын шаардлагуудыг даган мөрдөнө. Энэ нь тухайлбал, тайлагнагч байгууллага болох нийт засгийн газрын зөвхөн үндсэн секторын хувьд төсвийг бэлтгэдэг бол 1.7.8-р параграфтаар шаардсан тодруулгыг тухайн засгийн газрын зөвхөн үндсэн секторын хувьд хийнэ гэсэн үг юм.

### **Толилуулга**

- 1.7.17 ***Санхүүгийн тайлан ба төсвийг зөвхөн зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэг тохиолдолд байгууллага нь төсвийн дүн болон гүйцэтгэлийн дүн хоорондох зэрэгцүүлэлтийг мөнгөн орлого, зарлагын тайланд төсвийн нэмэлт багана оруулах байдлаар толилуулна.***
- 1.7.18 Төсвийн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусдаа санхүүгийн тайлан (“төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайлан” буюу үүнтэй адилтгах нэршил бүхий тайлан)-д толилуулж болно. Өөр нэг хувилбар бол, санхүүгийн тайлан болон төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар, өөрөөр хэлбэл тухайн нэг байгууллагын хувьд ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн сууриар бэлтгэдэг бөгөөд нэг ижил ангиллын бүтцийг мөрддөг тохиолдолд энэхүү Стандартын дагуу толилуулсан мөнгөн орлого, зарлагын тайланд нэмэлт багана оруулж болох юм. Анхны ба тодотгосон төсвийн дүн, түүнчлэн тухайн байгууллага хүсвэл уг төсвийн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох зөрүүг эдгээр нэмэлт багананд тусган харуулдаг.
- 1.7.19 Төсөв ба санхүүгийн тайланг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэггүй тохиолдолд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайланг тусад нь толилуулна. Ийм тохиолдолд өөр өөр сууриудаар бэлтгэсэн санхүүгийн мэдээллийг хэрэглэгч нар буруу ойлгохоос сэргийлэхийн тулд төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн сууриуд ялгаатай бөгөөд Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайланг төсвийн сууриар бэлтгэсэн гэдгийг санхүүгийн тайланд зохих ёсоор тодруулж болох юм.

### **Нэгтгэлийн түвшин**

- 1.7.20 Төсвийн баримт бичиг нь тодорхой үйл ажиллагаа, хөтөлбөр буюу байгууллагын талаархи маш дэлгэрэнгүй мэдээллээр хангаж болох юм.

Эдгээр дэлгэрэнгүй мэдээллийг тухайн төсвийн үндсэн бүрэлдэхүүний дагуу ерөнхий ангиуд, төсвийн ангилал эсвэл хууль тогтоогч болон бусад эрх бүхий байгууллагад толилуулах ба тэднээр батлуулахад зориулсан төсвийн бүрэлдэхүүнээр ихэвчлэн нэгтгэдэг. Эдгээр ерөнхий ангиуд ба төсвийн бүрэлдэхүүнтэй нийцсэн төсвийн болон гүйцэтгэлийн мэдээллийн тодруулга нь уг төсвийн баримт бичигт тодорхойлсон, хууль тогтоох буюу бусад эрх бүхий байгууллагуудын хяналтын түвшнээр зэрэгцүүлэлтийг хийх боломж бүрдүүлдэг.

- 1.7.21 Зарим тохиолдолд, батлагдсан төсөвт тусгасан уг дэлгэрэнгүй санхүүгийн мэдээллийг энэ Стандартын шаардлагуудын дагуу санхүүгийн тайланд толилуулахын тулд нэгтгэх шаардлагатай байж болох юм. Мэдээллийн хэт ачаалал үүсгэхээс зайлсхийх ба хууль тогтоох буюу бусад эрх бүхий байгууллагуудын хяналтын холбогдох түвшинг тусгахад ийм нэгтгэл зайлшгүй шаардлагатай байж болно. Нэгтгэлийн түвшинг тодорхойлохдоо мэргэжлийн шүүн тунгаалт хийдэг. Энэ Стандартын зорилгын агуулга болон мөн уг Стандартын 1.3.27-р параграфт дурдсан, санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг харгалзан ийм шүүн тунгаалтыг хийнэ.
- 1.7.22 Төсвийн нэмэлт мэдээлэл, үүн дотроо үйлчилгээний үр дүнгийн талаархи мэдээллийг санхүүгийн тайлангаас өөр бусад баримт бичигт толилуулж болох юм. Санхүүгийн тайлангаас ийм баримт бичгүүдэд харилцан лавлагаа үүсгэхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн байдаг.

#### **Анхны төсвөөс тодотгосон төсөв болгох өөрчлөлт**

- 1.7.23 ***Анхны төсөв ба тодотгосон төсвийн хоорондох өөрчлөлт нь тухайн төсвийн доторх дахин хуваарилалтын эсвэл бусад хүчин зүйлсийн үр дагавар эсэх талаархи тайлбарыг байгууллага нь дараах байдлаар толилуулна:***
- (а) ***Санхүүгийн тайлан дахь тэмдэглэл тодруулга байдлаар; эсвэл***
- (б) ***Санхүүгийн тайланг гаргахаас өмнө, гаргах үед эсвэл түүнтэй хамт гаргасан тайлан илтгэлд оруулах ба тэрхүү тайланд үүсгэсэн харилцан лавлагааг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад тусгах.***
- 1.7.24 Тодотгосон төсөв нь анхны төсвийг хянан засварлах хууль ёсны ажиллагаа буюу бусад олгогдсон бүрэн эрхийн дагуу баталсан бүх өөрчлөлтүүдийг агуулсан байдаг. Энэ Стандартын шаардлагуудын дагуу, анхны төсөв ба тодотгосон төсвийн хоорондох өөрчлөлтийн талаархи тайлбарыг санхүүгийн тайлангийн тодруулгад эсвэл тухайн санхүүгийн тайланг гаргахаас өмнө, гаргах үед эсвэл түүнтэй хамт гаргасан тусдаа тайлан илтгэлд тусгана. Өөрчлөлт нь тухайлбал, анхны төсвийн параметруудийн хүрээнд дахин хуваарилалт хийсний үр дүнд, эсвэл төсвийн ерөнхий параметруудийн өөрчлөлт, үүн дотроо засгийн газрын бодлогын өөрчлөлт гэх мэт бусад хүчин зүйлсийн үр дүнд үүссэн эсэхийг уг тайлбарт тусгана.

Санхүүгийн тайлангийн нэг хэсэг байдлаар биш боловч түүнтэй хамт гаргасан удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ буюу үйл ажиллагааны талаархи адилтгах тайланд ийм тодруулгыг ихэвчлэн хийдэг. Төсвийн хэрэгжилтийг тайлагнахын тулд засгийн газраас гаргасан төсвийн үр дүнгийн тайланд ийм тодруулгыг бас хийж болно. Тодруулгыг санхүүгийн тайланд бус, харин тусдаа тайланд хийсэн тохиолдолд уг тайлантай холбосон харилцан лавлагааг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад харуулна.

### **Зэрэгцүүлэгдэх суурь**

1.7.25 ***Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох бүх зэрэгцүүлэлтийг тухайн төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар толилуулна.***

1.7.26 Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг тухайн нэг байгууллагуудын хувьд уг батлагдсан төсөвтэй ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн суурь (аккруэл, мөнгөн буюу бусад суурь) болон нэг ижил ангиллын сууриар толилуулна. Төсвийн даган мөрдөлтийн талаархи санхүүгийн тайлан дахь мэдээллийн тодруулга нь уг төсөвтэй ижил сууриар хийгдсэн гэдгийг энэ нь ханган магадалдаг. Энэ нь төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлэлтийг янз бүрийн бүлэг үйл ажиллагааны хувьд нягтлан бодох бүртгэлийн өөр сууриар болон тухайн санхүүгийн тайланд мөрдсөнөөс ялгаатай, толилуулгын буюу ангиллын хэв загвараар зарим тохиолдолд толилуулдаг гэсэн утгыг илэрхийлж болох юм.

1.7.27 1.7.10-р параграфт дурдсанчлан, тухайн тайлагнагч байгууллагыг бүрдүүлж буй бие даасан байгууллагууд буюу тодорхой үйл ажиллагаануудын хувьд тусдаа төсөв баталж, олон нийтэд нээлттэй танилцуулж болох юм. Ингэж тусдаа төсөв бэлтгэдэг тохиолдолд энэхүү Стандартын шаардлагууд болон сайшаан дэмжилтийн дагуу тухайн санхүүгийн тайланд толилуулах зорилгоор тэдгээр тусдаа төсвүүдийг дахин нэгтгэн бүрдүүлж болно. Ийм дахин нэгтгэн бүрдүүлэлтийг хийх үедээ уг батлагдсан төсвийн өөрчлөлт буюу хянан засварлалтыг түүнд тусгадаггүй. Яагаад гэвэл, энэ Стандарт нь гүйцэтгэлийн дүнг уг батлагдсан төсвийн дүнтэй зэрэгцүүлэхийг шаарддаг.

1.7.28 Байгууллагууд нь өөрсдийн санхүүгийн тайлангийн бэлтгэлт болон батлагдсан төсөвтөө нягтлан бодох бүртгэлийн өөр өөр сууриудыг мөрдөж болох юм. Жишээлбэл; цөөн боловч зарим тохиолдолд засгийн газар буюу засгийн газрын агентлаг нь өөрийн санхүүгийн тайландаа мөнгөн суурийг, төсөвтөө аккруэл суурийг мөрдөж болно. Мөн түүнчлэн, санхүүгийн тайланд мөнгөн орлого, мөнгөн зарлага болон үлдэгдлийг тайлагнадаг боловч төсөв нь ирээдүйд мөнгө санг зарцуулах амлалтууд ба тэдгээр амлалтын өөрчлөлтүүдийн талаархи мэдээлэлд голлон чиглэх буюу түүнийг агуулсан байж болно. Гэхдээ төсөв бэлтгэж буй байгууллага болон санхүүгийн тайлагналын байгууллага нь ихэвчлэн нэг ижил байгууллага байдаг. Үүнтэй адилаар, төсвийг бэлтгэсэн хугацаа болон тухайн төсөвт мөрдсөн ангиллын суурийг санхүүгийн тайланд ихэвчлэн тусгадаг. Энэ нь тухайлбал, уг төсвийн хугацааны туршид төсвийн хэрэгжилтийн явцыг

хянан удирдах, түүнчлэн засгийн газар, олон нийт ба бусад хэрэглэгчдэд зохих ёсоор, цаг хугацаанд нь тайлагнах удирдлагын болон хариуцлагын зорилгоор төсөв ба гүйцэтгэлийн мэдээний зэрэгцүүлэлт хийх боломжтой байдлаар санхүүгийн мэдээллийг тухайн нягтлан бодох бүртгэлийн систем бүртгэж, тайлагнаж байгаа гэдгийг ханган магадалдаг.

1.7.29 Тухайн санхүүгийн тайланд тусгагдсан байгууллага, үйл ажиллагаанаас өөр байгууллагууд болон үйл ажиллагаануудыг агуулдаг статистикийн тайлагналын системтэй нийцсэн мөнгөн эсвэл аккрузл сууриар зарим улс оронд төсвийг бэлтгэж болох юм. Жишээлбэл; санхүүгийн тайлан нь засгийн газрын хянадаг бүх үйл ажиллагаанууд, үүн дотроо тухайн засгийн газрын бизнесийн үйл ажиллагааны талаар тайлагнадаг бол статистикийн тайлагналын системд нийцүүлэн бэлтгэсэн төсөв нь засгийн газрын үндсэн секторт голлон чиглэдэг бөгөөд өөрийн үндсэн үйл ажиллагаа байдлаар засгийн газрын “анхдагч” буюу “зах зээлийн бус” чиг үүргийг зөвхөн биелүүлдэг байгууллагуудыг хамарсан байж болох юм.

1.7.30 Статистикийн тайлагналын загварын хувьд засгийн газрын үндсэн сектор нь үндэсний, мужийн/бүсийн болон орон нутгийн засгийн газрын түвшингүүдээс бүрдэж болох юм. Зарим улс орны хувьд, үндэсний засгийн газар нь мужийн/бүсийн болон орон нутгийн засгийн газруудыг хянаж, тэдгээр засгийн газруудыг өөрийн санхүүгийн тайландаа нэгтгэдэг бөгөөд засгийн газрын эдгээр бүх гурван түвшинг агуулдаг уг батлагдсан төсвийг боловсруулж, олон нийтэд нээлттэй танилцуулахыг шаарддаг байж болно. Ийм тохиолдолд, үндэсний засгийн газрын тэдгээр байгууллагуудын санхүүгийн тайланд энэхүү Стандартын шаардлагуудыг мөрдөнө. Гэвч үндэсний засгийн газар нь мужийн/бүсийн буюу орон нутгийн засгийн газруудыг хянадаггүй тохиолдолд түүний санхүүгийн тайланд мужийн/бүсийн буюу орон нутгийн засгийн газруудыг нэгтгэхгүй. Харин засгийн газрын түвшин тус бүрийн хувьд тусдаа санхүүгийн тайланг бэлтгэдэг. Засгийн газрын байгууллагын хянадаг байгууллагууд болон үйл ажиллагаанууд эсвэл тэдгээрийн дэд хэсгүүдийн хувьд батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаг зөвхөн тийм тохиолдолд уг засгийн газрын байгууллагын санхүүгийн тайланд энэхүү Стандартын шаардлагуудыг мөрдөнө.

### **Олон жилийн төсөв**

1.7.31 Зарим засгийн газар болон бусад байгууллагууд нь тусдаа жилийн төсвийг биш, харин олон жилийн төсвийг бэлтгэж, олон нийтэд нээлттэй танилцуулдаг. Уламжлал ёсоор, олон жилийн төсөв нь хэд хэдэн жилийн төсөв буюу жилийн төсвийн зорилтуудаас бүрддэг. Бүрэлдэхүүн хэсэг болох жилийн тайлант үе бүрийн хувьд батлагдсан төсөв нь уг олон жилийн төсөвтэй холбоотой төсөвлөлтийн бодлогыг тэрхүү бүрэлдэхүүн тайлант үед хэрхэн мөрдөхийг тусгадаг. Зарим тохиолдолд, олон жилийн төсөв нь аливаа нэг жилийн хувьд ашиглагдаагүй төсвийн хуваарилалтын дараагийн жилүүд дэх шилжүүлэлтийг харуулдаг.

1.7.32 Олон жилийн төсөв бүхий засгийн газар ба бусад байгууллагууд нь төсвөө хэрхэн баталдагаас хамааран өөрсдийн анхны болон тодотгосон төсвөө тодорхойлохдоо янз бүрийн арга хандлагуудыг ашиглаж болох юм. Жишээлбэл; засгийн газар нь хоёр жилийн төсвийг агуулсан хоёр тайлант жилийн төсвийг баталж болох бөгөөд энэ тохиолдолд жил тус бүрийн батлагдсан анхны болон тодотгосон төсвийг тодорхойлох боломжтой байдаг. Хэрэв хоёр жилийн төсвийн эхний жилийн ашиглагдаагүй үлдсэн төсвийн хуваарилалтыг хоёр дахь жилд зарцуулахыг хууль ёсоор зөвшөөрдөг бол энэхүү өмнөх жилээс “шилжиж ирсэн” дүнгээр уг хоёр дахь жилийн “анхны” төсвийг нэмэгдүүлнэ. Засгийн газар нь жил тус бүрд хамаарах төсвийн дүнг тусгайлан салган харуулаагүй хоёр буюу бусад олон жилийн төсвийг баталдаг цөөн ховор тохиолдолд энэ Стандартын зорилгоор жилийн төсвийг тодорхойлохдоо, жил тус бүрд аль дүнгүүд хамаарахыг тогтоохын тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байж болох юм. Жишээлбэл; хоёр жилийн төсвийн эхний жилийн хувьд батлагдсан анхны болон тодотгосон төсөв нь эхний жилийн туршид хийгдэх уг хоёр жилийн аливаа батлагдсан капитал худалдан авалт, түүнчлэн тухайн жилд хамааруулж болох дахин давтагдах орлого ба зарлагын зүйлсийн дүнг агуулсан байдаг. Эхний жилээс зарцуулагдаагүй үлдсэн аливаа дүнг дараа нь хоёр дахь жилийн “анхны” төсөвт оруулах бөгөөд түүний аливаа нэмэлт өөрчлөлтийн хамтаар тухайн төсөв нь тэрхүү хоёр дахь жилийн тодотгосон төсөв болох юм. Тухайн төсвийн жилийн турш дахь төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох уялдаа холбооны талаар тодруулга хийхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн байдаг.

### **Төсвийн суурь, хугацаа, цар хүрээний тэмдэглэл тодруулга**

1.7.33 ***Байгууллага нь уг батлагдсан төсөвт хэрэглэсэн төсөвлөлтийн суурь болон ангиллын суурийг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тайлбарлана.***

1.7.34 Төсвийг бэлтгэж, толилуулахад ашигласан нягтлан бодох бүртгэлийн суурь (мөнгөн, аккруэл буюу тэдгээрийн зарим сайжруулалт) ба санхүүгийн тайланд ашигласан нягтлан бодох бүртгэлийн суурь нь өөр өөр байж болох юм. Нягтлан бодох бүртгэлийн систем ба төсвийн систем нь мэдээллийг өөр өөр төлөв байдлаас бэлтгэж бүрдүүлдэг тохиолдолд ийм зөрүү үүсэж болно. Тухайлбал; санхүүгийн тайлан нь мөнгөн орлого, мөнгөн зарлагыг тайлагнадаг бол төсөв нь мөнгөн гүйлгээ, түүнчлэн зарим хуримтлуулалт болон амлалтанд голлон чиглэдэг байж болно.

1.7.35 Батлагдсан төсвийг толилуулахад хэрэглэсэн хэлбэр болон ангиллын бүтэц нь санхүүгийн тайланд хэрэглэсэн хэлбэр, загвараас мөн өөр байж болно. Батлагдсан төсөв нь санхүүгийн тайланд хэрэглэсэнтэй ижил сууриар зүйлсийг тухайлбал, эдийн засгийн мөн чанараар (ажиллагчдын цалин хөлс, хангамжийн болон хэрэглээний зүйлс, буцалтгүй тусламж, шилжүүлэг гэх мэт) эсвэл чиг үүргээр (эрүүл мэнд, боловсрол гэх мэт) зарлагыг ангилж болох юм. Өөр нэг хувилбар бол, төсөв нь тусгай хөтөлбөрөөр (жишээлбэл; ядуурлыг бууруулалт, халдварт өвчний хяналт) эсвэл гүйцэтгэлийн үр дүнгийн зорилтуудтай холбоотой хөтөлбөрийн

бүрэлдэхүүн хэсгүүдээр (жишээлбэл; дээд боловсролын хөтөлбөрийг төгсөгч оюутнуудаар эсвэл эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээгээр хийсэн мэс заслын үйл ажиллагаагаар) зүйлсийг ангилж болох бөгөөд энэ нь санхүүгийн тайланд хэрэглэсэн ангиллаас өөр байдаг. Түүнчлэн, тасралтгүй үйл ажиллагааны (жишээлбэл; боловсрол буюу эрүүл мэнд) дахин давтагдах төсвийг капитал зарлагад (жишээлбэл; дэд бүтэц буюу барилга байгууламж)-д зориулсан капитал төсвөөс тусад нь баталж болох юм.

- 1.7.36 Батлагдсан төсвийг бэлтгэж, толилуулахад мөрдсөн төсөвлөлтийн суурь ба ангиллын суурийн талаархи тодруулга нь уг санхүүгийн тайланд тодруулсан төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн хоорондох уялдаа холбоог илүү сайн ойлгоход хэрэглэгчдэд тусалдаг.
- 1.7.37 ***Байгууллага нь уг батлагдсан төсвийн тайлант хугацааг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад тусгаж тодруулна.***
- 1.7.38 Санхүүгийн тайланг наад зах нь жил бүр бэлтгэж толилуулна. Байгууллагууд нь төсвийг жилээр эсвэл олон жилээр бэлтгэн баталж болох юм. Батлагдсан төсөвт хамаарах тайлант хугацаа нь санхүүгийн тайланд хэрэглэсэн тайлант хугацаанаас өөр байх тохиолдолд тэрхүү тайлант хугацааны талаархи тодруулга нь санхүүгийн тайлантай уг төсвийн мэдээ болон төсвийн зэрэгцүүлэлтийн холбогдох уялдаа холбоог тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар илүү сайн ойлгоход тусалдаг. Батлагдсан төсөвт хамаарах тайлант хугацаа нь санхүүгийн тайланд хамрагдах тайлант хугацаатай ижил байх тохиолдолд тэрхүү тайлант хугацааны талаархи тодруулга нь ялангуяа завсрын хугацааны төсөв, санхүүгийн тайлан болон бусад тайлан илтгэлийг бас бэлтгэдэг улс орнуудын хувьд мөн баталгаажуулах чухал үүргийг гүйцэтгэдэг.
- 1.7.39 ***Байгууллага нь уг батлагдсан төсөвт хамаарах байгууллагуудыг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад тусган тодорхойлно.***
- 1.7.40 Хяналт тавигч байгууллагууд нь тухайн засгийн газрын хянаж буй төсвөөс хамааралтай байгууллагууд болон улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудыг агуулсан тийм нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахыг энэ Стандартын Хоёрдугаар хэсгийн 2.1.37-р параграфтаар сайшаан дэмжсэн байдаг. Гэвч 1.7.29-р параграфт тэмдэглэсэнчлэн, статистикийн тайлагналын загварын дагуу бэлтгэдэг, батлагдсан төсөв нь худалдаа арилжааны буюу зах зээлийн сууриар хийгддэг тухайн засгийн газрын үйл ажиллагаануудыг хамруулан тусгаагүй байж болох юм. 1.7.25-р параграфын шаардлагуудын дагуу төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийг зэрэгцүүлэгдэх сууриар толилуулна. Төсөвт багтан хамрагдсан байгууллагуудын талаархи тодруулга нь тухайн байгууллагын үйл ажиллагаа тэрхүү батлагдсан төсөвт хамаарах хэмжээ, түүнчлэн тус төсөвт байгууллага нь уг санхүүгийн тайланд тусгагдсан байгууллагаас ямар ялгаатайг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог.

**Зэрэгцүүлэгдэх сууриар тусгасан гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайлан дахь гүйцэтгэлийн дүнгийн хоорондох тохируулга**

1.7.41 *Санхүүгийн тайлан ба төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэггүй тохиолдолд 1.7.25-р параграфын дагуу төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар толилуулсан гүйцэтгэлийн дүнг нийт мөнгөн орлого ба нийт мөнгөн зарлагатай тохируулж, аливаа суурь, цаг хугацаа болон байгууллагын зөрүүтэй байдлыг тусад нь тодорхойлно. Уг тохируулгыг төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайланд эсвэл санхүүгийн тайлангийн тэмдэглэлд хэсэгт тодруулж тусгана.*

1.7.42 Зэрэгцүүлэгдэх суурьтай нийцүүлэн тодорхойлсон гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн гүйцэтгэлийн дүнгийн хоорондох зөрүүг дараах байдлаар зохих ёсоор ангилж болно:

- (а) Төсөвлөлтийн суурийн зөрүү, энэ нь уг батлагдсан төсвийг нягтлан бодох бүртгэлийн сууриас өөр сууриар бэлтгэсэн үед үүсдэг. Жишээлбэл; төсвийг аккруэл сууриар эсвэл тохируулсан мөнгөн сууриар бэлтгэдэг, харин санхүүгийн тайланг мөнгөн сууриар бэлтгэдэг байх;
- (б) Цаг хугацааны зөрүү, энэ нь тухайн санхүүгийн тайланд тусгасан тайлант хугацаанаас уг төсвийн тайлант хугацаа өөр байх үед үүсдэг; ба
- (в) Байгууллагын зөрүү, энэ нь санхүүгийн тайланг бэлтгэж буй тухайн байгууллагын нэг хэсэг болох байгууллагууд эсвэл хөтөлбөрүүдийг төсөвт тусгахгүй байх тохиолдолд үүсдэг.

Мөн санхүүгийн тайлангийн болон төсвийн толилуулгын хувьд хэрэглэсэн хэлбэр загвар ба ангиллын бүтцийн хувьд өөр байж болох юм.

1.7.43 Энэ Стандартын 1.7.41-р параграфтаар шаардсан тохируулга нь төсвийн сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн ба мөнгөн орлого, зарлагын тайланд хүлээн зөвшөөрсөн нийт мөнгөн орлого, нийт мөнгөн зарлагын хоорондох зөрүүгийн гол эх үүсвэрүүдийг тогтоосноор өөрийн хариуцлагын үүргийг илүү сайн биелүүлэх боломжийг тухайн байгууллагад олгодог. Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтэнд толилуулсан гол нийт дүн болон дэд дүн нэг бүрийг эсвэл зүйлсийн анги тус бүрийг тухайн санхүүгийн тайлан дахь адилтгах дүнгүүдтэй тохируулахыг энэ Стандартаар хориглодоггүй.

1.7.44 Төсвийн баримт бичиг ба санхүүгийн тайлангийн аль алиныг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг мөрддөг байгууллагуудын хувьд, төсвийг санхүүгийн тайлантай нэг ижил хугацаагаар бэлтгэдэг, төсөвт нэг ижил байгууллагуудыг тусган оруулдаг, санхүүгийн тайлантай ижил толилуулгын хэлбэр загварыг ашигладаг бол тохируулга хийх шаардлагагүй байдаг. Төсөв болон санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нэг ижил суурийг мөрддөг өөр бусад байгууллагуудын хувьд



толилуулгын хэлбэр загвар, тайлагнагч байгууллага эсвэл тайлант үе нь өөр өөр байж болно. Жишээлбэл; тухайн батлагдсан төсөв нь санхүүгийн тайлангаас өөр ангилал буюу толилуулгын хэлбэр загварыг мөрддөг, уг байгууллагын зөвхөн худалдаа арилжааны бус үйл ажиллагааг тусгадаг эсвэл олон жилийн төсөв байж болно. Нягтлан бодох бүртгэлийн нэг ижил сууриар бэлтгэдэг төсөв ба санхүүгийн тайлангийн хооронд толилуулгын, цаг хугацааны эсвэл байгууллагын зөрүүтэй тохиолдолд ийм тохируулга хийх зайлшгүй шаардлагатай юм.

**1.7.45** *Өмнөх тайлант үеийн хувьд энэ Стандартын шаардлагуудын дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулга хийх шаардлагагүй юм.*

1.7.46 Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллагуудын санхүүгийн тайланд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг тусгахыг энэ Стандартаар шаарддаг. Энэ Стандарт нь өмнөх тайлант үеийн гүйцэтгэлийг тэрхүү өмнөх тайлант үеийн төсөвтэй зэрэгцүүлсэн тодруулга хийхийг шаарддаггүй, мөн уг өмнөх тайлант үеийн гүйцэтгэл ба төсвийн хоорондох зөрүүгийн талаархи холбогдох тайлбаруудыг тухайн тайлант үеийн санхүүгийн тайланд тодруулахыг шаарддаггүй.

## **1.8 Нэгдүгээр хэсгийн хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилтийн нөхцлүүд**

### **Шилжилтийн нөхцлүүд**

1.8.1 *Мөнгөн суурьт УСНББОУС, “Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал”-ыг анх удаа мөрдөж буй байгууллагууд нь уг анх мөрдсөн өдрөөс эхлэн түүний бүх нөхцлүүдийг дагаж мөрдөх хэрэгтэй.*

1.8.2 *Хүчингүй болсон Мөнгөн суурьт УСНББОУС, “Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал”-ын дагуу санхүүгийн тайлангаа одоо толилуулж буй байгууллагууд нь энэ Стандартын шаардлагуудыг 2019 оны 01 дүгээр сарын 01 хүртэл даган мөрдөх шаардлагагүй юм.*

1.8.3 *Байгууллага нь 1.8.2-р параграфт заасан шилжилтийн нөхцлийг мөрддөг тохиолдолд тус байгууллага нь хараахан мөрдөж эхлээгүй байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг тодруулна.*

1.8.4 Байгууллага нь Мөнгөн суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдөж байгаа тохиолдолд уг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах тухайн байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө. Одоогоор Мөнгөн суурьт УСНББОУС-ыг мөрдөж буй байгууллагууд нь энэ Стандартын хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн түүний бүх нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг мөрдөхөд хоёр хүртэл жилийн хугацааг уг шилжилтийн нөхцлөөр олгодог. Тус шилжилтийн нөхцлүүдийн давуу талыг ашиглаж буй байгууллагууд нь түүнтэй бүрэн нийцэхгүй байгаа өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг ялган

тодорхойлох хэрэгтэй. Энэ Стандартыг мөрдсөний үр дүнд түүний нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон бүх өөрчлөлтүүдийг доорх 1.8.11-1.8.13-р параграфын шаардлагуудын дагуу тайлагнах хэрэгтэй.

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

- 1.8.5 ***Байгууллага нь энэ Стандартыг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг дэмжинэ. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.***
- 1.8.6 Мөнгөн суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдөж буй байгууллага болон Мөнгөн суурьт УСНББОУС-ыг угаасаа мөрддөг байгууллага нь энэ Стандартыг дагаж мөрдөнө.

### **Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-аас татгалзах**

- 1.8.7 ***Энэ Стандарт нь 2007 онд гаргасан Мөнгөн суурьт УСНББОУС, “Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал”-ыг орлоно.***
- 1.8.8 Мөнгөн суурьт УСНББОУС-ыг анх 2003 оны 01 дүгээр сард гаргасан. Уг Стандартыг 2004 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрддөг байсан. Төсвийн тайлагнал ба гадаад тусламжийг зохицуулах нэмэлт шаардлагууд болон сайшаан дэмжилтээр тус Стандартыг дараа нь буюу 2006, 2007 онд шинэчлэн баяжуулсан. Энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн Хэсэг 9, “*Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга*” ба Хэсэг 10, “*Гадаад тусламж хүлээн авагчид*”-ын нэмэлт шаардлагууд нь 2009 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.8.9 Энэ Стандартыг 2017 онд гаргасан. Энэ нь өмнө гаргасан байсан 2007 оны Стандартыг орлох юм. 2007 оны Стандартын Нэгдүгээр хэсэгт тусгасан, нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэлт болон гуравдагч талын төлбөр, гадаад тусламжийн талаархи мэдээллийн тодруулгын шаардлагаас чөлөөлөх нөхцөл оруулахын тулд тус Стандартыг хянан засварласан. Эдгээр шаардлагуудын заримыг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн зүйл байдлаар одоо тусган оруулсан. *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* (Онолын Үзэл Баримтлал) болон одоо гаргасан байгаа аккрузл УСНББОУС-тай тохиромжтой бол илүү сайн нийцүүлэхийн тулд энэ Стандартад мөн нэмэлт өөрчлөлт оруулсан.
- 1.8.10 Энэхүү Стандартын Нэгдүгээр ба Хоёрдугаар хэсгийн шаардлагууд болон сайшаан дэмжилтийн нэгдэл нь уг хүчингүй болсон стандартын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд толилуулсан, бүх биш боловч холбогдох

олон мэдээллийг энэ Стандартын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд бас толилуулна гэсэн утгыг илэрхийлдэг. Гэвч уг хүчингүй болсон стандартад нийцүүлэн санхүүгийн тайлангаа толилуулсан байгууллагууд нь энэ Стандартын шаардлагууд болон сайшаан дэмжилттэй нийцсэн хэвээр байгаа эсэхийг ханган магадлахын тулд тэдгээрийг нягталж шалгах шаардлагатай юм.

### **Хүчингүй болгосон, Мөнгөн суурьт УСНББОУС-ыг мөрддөг байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**

- 1.8.11 *Энэ Стандартын мөрдөлт нь хүчингүй болсон Мөнгөн суурьт УСНББОУС-ыг одоогоор мөрдөж буй байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулахыг шаарддаг тохиолдолд тус байгууллага нь толилуулсан тухайн тайлант үеийн мөнгөний эхний үлдэгдэл болон толилуулсан яг өмнөх тайлант үеийн хувьд тодруулсан бусад зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг уг нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг угаасаа мөрдөж байсан бол ямар байх байсан тийм байдлаар тохируулснаар тэрхүү өөрчлөлтийг буцаах горимоор мөрдөнө.*
- 1.8.12 *Хүчингүй болсон Мөнгөн суурьт УСНББОУС-ыг одоогоор мөрдөж буй байгууллага нь толилуулсан яг өмнөх тайлант үед тэрхүү нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг мөрдсөний нийт хуримтлагдсан үр нөлөөг тухайн тайлант үеийн эхний байдлаар тодорхойлох практик боломжгүй тохиолдолд тус байгууллага нь:*
- (a) *Бодлогыг өөрчилсөн өдрөөс хойш гарч тохиолдсон ажил гүйлгээ, бусад үйл явдал болон нөхцөл байдалд нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг мөрдөнө; ба*
  - (б) *Тухайн тайлант үеийн болон уг өөрчлөлтөнд хамаарах ирээдүйн тайлант үеүдийн мөнгөн орлого, зарлага, үлдэгдэлд тэрхүү шинэ бодлогын үзүүлэх үр нөлөөг хүлээн зөвшөөрнө.*
- 1.8.13 *Хүчингүй болсон Мөнгөн суурьт УСНББОУС-ыг одоогоор мөрдөж буй байгууллага нь энэ Стандартыг анх мөрдөх үед (а) тухайн тайлант үед буюу яг өмнөх тайлант үед үр нөлөөтэй, эсвэл (б) залруулгын дүнг тодорхойлох практик боломжгүй байхаас бусад тохиолдолд ийм үр нөлөөтэй байхаар байсан бол тус байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:*
- (a) *Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн шинж төрөл;*
  - (б) *Тухайн тайлант үе болон толилуулсан яг өмнөх тайлант үеийн хувьд практик боломжтой тохиолдолд уг санхүүгийн тайлангийн холбогдох мөрийн зүйл бүрд хийгдэх залруулгын дүн; ба*
  - (в) *1.8.11-р параграфтаар шаардсан буцаах горимоор мөрдөх практик боломжгүй бол ийм байдалд хүргэсэн нөхцөл байдал,*

***уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг хэрхэн,  
хэзээнээс мөрдсөн талаархи тайлбар тодорхойлолт.***

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС, “Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал”-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

*Энэ Стандартын Хоёрдугаар хэсгийг дагалдах Дүгнэлтийн Үндэслэл нь уг Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн зүйлсийн нэмэлт өөрчлөлтүүдийг авч үзнэ.*

### Оршил

ДҮ1. УСНББОУС, “Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал” (Мөнгөн суурьт УСНББОУС)-ыг 2003 оны 01 дүгээр сард гаргасан бөгөөд төсвийн мэдээллийн толилуулгын талаархи нэмэлт шаардлагууд болон сайшаан дэмжилтээр 2006 онд, харин гадаад тусламжийн толилуулгын нэмэлт шаардлагууд болон сайшаан дэмжилтээр 2007 онд түүнийг шинэчлэн баяжуулсан. Энэ нь хоёр хэсгээс бүрддэг: Нэгдүгээр хэсэг нь нийтлэг зорилготой санхүүгийн тайландаа энэ Стандартыг баримталдаг тайлагнагч байгууллагын мөрдөх ёстой шаардлагуудыг тодорхойлдог. Хоёрдугаар хэсэг нь хариуцлагын ба шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой нэмэлт мэдээллээр хангах, түүнчлэн санхүүгийн санхүүгийн тайлагналын аккруэл суурьт болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжиж буй байгууллагуудад дэмжлэг үзүүлэхийн тулд сайшаан дэмжсэн нэмэлт тодруулгуудыг тодорхойлдог.

*Энэхүү нягтлах шалгалтын шалтгаан ба цар хүрээ*

ДҮ2. Энэхүү Мөнгөн суурьт УСНББОУС-ыг хэр олон засгийн газар ба улсын секторын бусад байгууллагууд мөрддөг талаар янз бүрийн үзэл бодолтой боловч өргөнөөр мөрддөггүй гэсэн нийтлэг ойлголттой байдаг. УСНББОУС-ын болон олон иргэд сонгогчдын, үүн дотроо УСНББОУС-ыг хэрэгжүүлэгч талуудын үйл ажиллагааг нягтлан шалгахын тулд үүсгэн байгуулсан УСНББОУС3-ийн Ажлын Хэсэг (УСНББОУС3-ийн Ажлын Хэсгийн Тайлан 2010) нь нэгтгэл, гадаад тусламж, гуравдагч талын төлбөрийн шаардлагуудыг уг Мөнгөн суурьт УСНББОУС-ын мөрдөлтийн гол саад бэрхшээл байдлаар тодорхойлсон.

ДҮ3. Хэдийгээр түүний мөрдөлт хязгаарлагдмал боловч Мөнгөн суурьт УСНББОУС-ыг түүний эрхийн хүрээнд Стандарт байдлаар, эсвэл санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжих эхний алхам байдлаар хэвээр хадгалах, түүнчлэн зарим тохиолдолд түүний мөрдөлтөнд учирч буй саад бэрхшээлийг арилгах шаардлагуудын хувьд хянан засварлалт хийх талаар хүчтэй дэмжлэг байгааг УСНББОУС3-ийн 2014 оны стратегийн зөвлөгөөнөөр тогтоосон. Санхүүгийн тайлагналын аккруэл суурьт шилжиж буй байгууллагууд нь аккруэл суурьт шилжихдээ мөрдөж болох хандлагуудын талаархи заавар удирдамжаар хангадаг УСНББОУС3-ийн Судалгаа 14, *Нягтлан Бодох Бүртгэлийн Аккруэл Суурьт Шилжилт: Улсын Секторын*

*Байгууллагуудад Зориулсан Удирдамж* (2011 оны 01 дүгээр сарын Гурав дахь хэвлэл)-ийг лавлагаа болгохыг мөн сайшаан дэмждэг.

- ДҮ4. Энэхүү хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017)-аар дамжуулан хийсэн нэмэлт өөрчлөлтүүд нь уг Мөнгөн суурьт УСНББОУС-ын үйл ажиллагааны талаар иргэд сонгогчдоос УСНББОУС3-ийн хүлээн авсан орц өгөгдлийн хариулт байдлаар тус УСНББОУС-д хийсэн хязгаарлагдмал хүрээний нягтлах шалгалтыг тусгадаг. Уг нэмэлт өөрчлөлтүүд нь дараах санаа зорилготой байдаг:
- (а) Нэгтгэл, гадаад тусламж, гуравдагч талын төлбөртэй холбоотой шаардлагуудаар илэрхийлэгдэх түүний мөрдөлтөнд учирч буй мэдэгдэхүйц саад бэрхшээлийг даван туулах; ба
  - (б) УСНББОУС3-ийн стандарт тогтоох стратегид энэхүү Мөнгөн суурьт УСНББОУС-ын үзүүлэхийг зорьж буй үүрэг нь түүнийг мөрдсөнөөр дуусах биш, харин аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдөх цаашдын замд юуны өмнө нэг алхам болно гэдгийг тодруулж өгөх.
- ДҮ5. Энэхүү хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017) нь “эмхлэн цэгцлэх” жижиг нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тусгасан бөгөөд хэдийгээр энэ Стандарт дахь шаардлагууд болон сайшаан дэмжилтүүд нь адилтгах аккруэл УСНББОУС-ын шаардлагуудаас өөр байж болох боловч энэ Стандартад мөнгөн суурийг голлон анхаарна гэдгийг тусгах зорилготой байхаас бусад шаардлагуудтай зөрчилдөхгүй гэдгийг тэрхүү нэмэлт өөрчлөлтөөр ханган магадлахыг эрмэлзсэн. Энэ Мөнгөн суурьт УСНББОУС-ыг 2003 онд гаргаснаас хойш аккруэл УСНББОУС-ыг шинэчлэн баяжуулж, зарим тохиолдолд хүчингүй болгох ба/буюу сольж орлуулсан. “Эмхлэн цэгцлэх” нэмэлт өөрчлөлтүүд нь аккруэл УСНББОУС-ын хөгжил өөрчлөлтийг тохиромжтой хэмжээгээр тусган харуулдаг.

### **Зөвлөлгөөн**

- ДҮ6. Энэ Стандартын шаардлагуудтай нийцсэн санхүүгийн тайлан бэлтгэх ба нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурьт санхүүгийн тайлагналын хамгийн сайн практикыг тусгахыг хүсэж буй улсын секторын олон байгууллагууд нь бүрэн нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэж, толилуулахад мэдэгдэхүйц саад бэрхшээлтэй тулгардаг. Энэ нь олон учир шалтгаантай байж болно. Үүнд: (а) төсвийн буюу засгийн газрын үндсэн секторын, эсвэл үйл ажиллагааны бусад бүлэглэлийн хувьд санхүүгийн тайлан илтгэл бэлтгэхийг шаарддаг одоогийн хууль тогтоомж болон зохицуулалттай нийцүүлэлт; (б) тухайн тайлангийн өдрөөр хяналтанд буй бүх байгууллагуудыг ялган тодорхойлоход хүндрэлтэй байдал; (в) улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудын мөрддөг тайлагналын суурийн ялгаатай байдал; (г) шаардлагатай мэдээг цаг хугацаанд нь цуглуулж, боловсруулах ба тайлагналын тогтоосон хугацааг биелүүлэх чадавхи.
- ДҮ7. Өмнөх нэгтгэлийн шаардлагууд нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангийн чанарыг сайжруулах,

санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ыг мөрдөх шилжилтэнд дэмжлэг үзүүлэх өөрийн үүргийг биелүүлэх уг Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-ын чадавхийг бууруулна, яагаад гэвэл засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагууд нь энэ Стандартыг даган мөрдөж чадахгүй гэдэгт санаа зовж буйгаа олон хүмүүс илэрхийлсэн. Доор дурдсанчлан, эдгээр санаа зовж буй асуудлуудад хариулт өгөхийн тулд Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-д энэхүү хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017)-аар нэмэлт өөрчлөлт оруулсан.

- ДҮ8. Хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэн тусгах тийм нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэнэ гэсэн шаардлагыг энэхүү хянан засварлалтаар тус Стандартын Нэгдүгээр хэсгээс хасаж, Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн зүйл байдлаар дахин тусган оруулсан. Энэ нь уг Стандартыг мөрдөхөд тулгарч буй гол саад бэрхшээлийг даван туулах санаа зорилготой юм.
- ДҮ9. Хяналтанд буй бүх байгууллагуудаа нэгтгэдэггүй, хяналт тавигч байгууллагууд нь санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжих үедээ төсвийн сектор, засгийн газрын үндсэн сектор буюу засгийн газрын гол үйл ажиллагааны бусад төлөөллийг тусгасан тийм санхүүгийн тайлан бэлтгэхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн байдаг. Энэ нь аккруэл УСНББОУС-аар шаардсан бүрэн нэгтгэлд дэс дараалалтай, зохих ёсоор шилжихэд дэмжлэг үзүүлэх бөгөөд бүрэн нэгтгэл нь засгийн газрын гол үйл ажиллагааны талаархи мэдээллийг орхигдуулдаг ба зарим тохиолдолд хууль тогтоомжийн шаардлагуудтай зөрчилддөг гэж зарим хүмүүсийн санаа зовж буй асуудалд хариулт өгдөг.
- ДҮ10. Аккруэл суурьт шилжиж буй байгууллагуудад дэмжлэг үзүүлэхийн тулд гол тодорхойлолтууд, үүн дотроо хяналтын тодорхойлолт нь УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан* ба УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-тай зөрчилдөөгүй гэдгийг ханган магадлахад шаардлагатай хэмжээгээр тэдгээр тодорхойлолтуудыг хянан засварласан.
- ДҮ11. Нэгтгэлийн одоогийн шаардлагуудын улмаас Стандартын мөрдөлтөнд учирч буй саад бэрхшээлийг арилгах олон арга хандлагуудыг УСНББОУС3 харгалзан үзсэн. Эдгээр олон арга хандлагууд нь ач тустай боловч Мөнгөн суурьт УСНББОУС-ыг хэрэгжүүлж буй хүмүүсийн, түүнчлэн хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгод ач холбогдолтой мэдээллийн хувьд уг УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд найдлага тавьдаг хүмүүсийн санаа зовж буй асуудлуудад энэхүү хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017)-ын арга хандлага нь хамгийн сайнаар хариулт өгнө гэж УСНББОУС3 нь холбогдох бүх хүчин зүйлсийг харгалзснаар дүгнэсэн. Харгалзан үзсэн бусад хандлагууд болон тэдгээрийн мөрдөлтийг УСНББОУС3 дэмжээгүй шалтгааныг доор дурдав:
- (а) Хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй бүх байгууллагуудаа нэгтгэнэ гэсэн шаардлагыг даган мөрдөхөд байгууллагуудад анх мөрдсөн өдрөөс хойш 3-5 жилийн эсвэл түүнээс урт шилжилийн

хугацааг олгох. Гэвч Мөнгөн суурьт УСНББОУС-ыг гаргаснаас хойш 12 гаруй жилийн хугацаа өнгөрсөн боловч нэгтгэл нь тус Стандартын мөрдөлтийн хувьд гол саад бэрхшээл хэвээр үлдсэн. 3-5 жилийн шилжилтийн хугацаа нь олон улс оронд тогтоон тодорхойлсон өргөн хүрээтэй, янз бүрийн саад бэрхшээлийг даван туулахад хангалттай гэж УСНББОУСЗ үзэхгүй байна;

- (б) Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэлт болон тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын бүрэлдэхүүн хэсгүүдийн тодруулгын хувьд баримтлах нягтлан бодох бүртгэлийн горимтой холбоотой шаардлагуудаас бусад, бүх нэгтгэлийн шаардлагуудыг сайшаан дэмжилт байдлаар дахин бүрдүүлэн тусгах. Ийм арга хандлага нь хүсүүштэй юм. Энэ нь аливаа нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхдээ баримтлах горимуудыг тухайн нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд нэг тайлант үеэс нөгөө тайлант үед, түүнчлэн уг УСНББОУС-ыг мөрдсөн бүх байгууллагуудад тууштай мөрдөх шаардлагууд байдлаар тодорхойлно гэсэн үг юм. Гэвч эдгээр асуудлуудыг шаардлага байдлаар тусган хадгалах нь тус УСНББОУС-ын мөрдөлтөнд тулгарах саад бэрхшээлийг илэрхийлсэн хэвээр байж болно. Мөн түүнчлэн, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бэлтгэлт ба толилуулгад чухал ач холбогдолтой зарим үйл явц болон тодруулгыг шаардлага байдлаар сонгох, харин өөр зарим үйл явц, тодруулгыг зөвхөн сайшаан дэмжилт байдлаар сонгох шалтгаан үндэслэлийг зөвтгөн батлахад хүндрэлтэй бөгөөд тус Стандартыг хэт нарийн төвөгтэй болоход хүргэх юм;
- (в) Нэгтгэлийн одоогийн шаардлагуудыг хэвээр хадгалах боловч улсын секторын худалдаа арилжааны байгууллагууд буюу улсын секторын байгууллагуудын зарим төвөгтэй ангиудыг нэгтгэх шаардлага гэх мэт практикын тодорхой саад бэрхшээлийн хувьд чөлөөлөх нөхцөл олгох. Уг хандлага нь иргэд сонгогчдын тодорхойлсон зарим саад бэрхшээлд хариулт өгөх ба иймээс хүсүүштэй байсан. Гэвч энэ нь иргэд сонгогчдын тодорхойлсон бүх саад бэрхшээлд хариулт өгөхгүй юм. Түүнчлэн, мөрдөлтийн тууштай байдлыг хангахын тулд улсын секторын худалдаа арилжааны байгууллага эсвэл улсын секторын байгууллагуудын зарим төвөгтэй анги гэдэгт юу хамаарах талаар харилцан зөвшөөрсөн тодорхойлолттой байхыг бас шаардана. Ийм тодорхойлолтыг бүх улс орнуудад шууд хэрэглэх боломжтой эсэх нь тодорхойгүй байсан; ба
- (г) Төсвийн сектор, засгийн газрын үндсэн сектор буюу хяналтанд буй бүх байгууллагуудыг биш, харин хяналтанд буй байгууллагуудын адилтгах завсрын бүлгийг тусгасан тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайланг толилуулахыг шаардах. Уг хандлага нь олон улсын орны иргэд сонгогчдын тодорхойлсон саад бэрхшээлд хариулт өгөх бөгөөд иймээс хүсүүштэй байсан. Гэвч ийм завсрын бүлгийг тодорхойлох буюу тусгайлан заах аливаа оролдлого нь зарим улс орны, ялангуяа хууль тогтоомжийн шаардлагууд нь тухайн тодорхойлсон завсрын бүлэгтэй шууд нийцдэггүй улс орны хувьд тодорхой саад бэрхшээл үүсгэж болох юм. Энэ нь аккреул



суурт шилжиж байгаа болон тусгайлан зааж болох завсрын бүлэг тайлагнагч байгууллагад өмнө нь шилжсэн улс орнуудын хувьд мөн саад бэрхшээл үүсгэж болох юм. Төсвийн сектор буюу засгийн газрын үндсэн секторыг тусган илэрхийлж буй бүлгийн санхүүгийн тайланг уг бүрэн аккрузл суурт шилжих явцад бэлтгэн толилуулж болно гэдгийг энэхүү хянан засварласан Мөнгөн суурт УСНББОУС (2017) хүлээн зөвшөөрч, тэмдэглэсэн.

### Гадаад тусламж

- ДҮ12. Гадаад тусламжийн нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурт санхүүгийн тайлагналд зориулсан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий шаардлагууд хэрэгцээтэй гэж үздэг тусламж хүлээн авагчид, донорууд болон санхүүгийн тайлагналын нийгэмлэгийн бусад олон талуудаас ирүүлсэн санал хүсэлтийн хариу ба дэмжлэг болгож, 2007 оны Мөнгөн суурт УСНББОУС-д гадаад тусламжийн талаархи мэдээллийн тодруулгын шаардлагууд болон сайшаан дэмжилтийг нэмж оруулсан.
- ДҮ13. Гэвч Стандартын шаардлагуудыг боловсруулж, УСНББОУС3-ийн албан үйл ажиллагаагаар дамжуулан гаргасны дараа, уг Мөнгөн суурт УСНББОУС (2007)-д тусган оруулах үед тус Стандартын шаардлагуудыг биелүүлэхийн тулд гадаад тусламж хүлээн авагчдад хэрэгцээтэй мэдээлэл нь УСНББОУС3-ийн болон түүний иргэд сонгогчдын урьдчилан таамагласны адилаар шууд бэлэн буюу хандан нэвтрэх боломжтой байгаагүй гэдгийг УСНББОУС3 мэдэж байсан. Мэдээлэл нь шууд бэлэн буюу шалгах боломжтой биш тохиолдолд тодруулгын шаардлагуудаас чөлөөлөх зарим нөхцлийг тус Мөнгөн суурт УСНББОУС (2007)-д заасан. Гэхдээ ийм чөлөөлөлтийн шаардлагатай хэмжээ, түүнчлэн тодруулсан мэдээллийн иж бүрэн ба үнэн зөв байдлыг шалгах боломжгүй байх нь тодруулсан аливаа үр дүнгийн мэдээллийн хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой байдлыг нэлээд буруулж болно гэдгийг УСНББОУС3 харгалзан үзсэн. Энэхүү хянан засварласан Мөнгөн суурт УСНББОУС (2017) нь доор дурдсанчлан, тэдгээр асуудлуудад хариулт өгсөн.
- ДҮ14. Тайлант үеийн туршид хүлээн авсан ба уг тайлангийн өдрөөр тухайн байгууллагад бэлэн боломжтой байгаа гадаад тусламжийн талаархи мэдээллийг тодруулах бүх шаардлагуудыг тус УСНББОУС-ын Нэгдүгээр хэсгээс хасаж, Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжилт байдлаар буцаан тусгасан бөгөөд мөнгө буюу гуравдагч талын төлбөр хэлбэрээр хүлээн авсан гадаад тусламжийн талаархи мэдээллийн тодруулгад анхаарал хандуулахын тулд түүнийг хянан засварласан. Мөнгөн суурт УСНББОУС (2017) нь тайлант үеийн туршид тухайн байгууллагын хүлээн авсан *бусад тусламж* (төрийн бус байгууллага болон бусад эх сурвалжаас авсан тусламж)-ийн талаархи адилтгах мэдээллийн тодруулга хийхийг мөн сайшаан дэмждэг.
- ДҮ15. Эдгээр шаардлагуудыг сайшаан дэмжилт дахин бүрдүүлэн тусгах нь тус УСНББОУС-ын мөрдөлтөнд тулгарч буй гол саад бэрхшээлийг даван туулна. Мөнгөн суурт УСНББОУС (2007)-д тусган оруулсан гадаад

тусламжийн талаархи мэдээллийн тодруулгын шаардлагууд нь дараах шинж чанартай гэж иргэд сонгогчдын санаа зовж байсан зүйлсэд энэ нь мөн хариулт өгсөн:

- (а) УСНББОУС-ын аккруэл суурьт тусгайлан зааснаас хэт дэлгэрэнгүй, төвөгтэй бөгөөд санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжихэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй нийцдэггүй байсан;
- (б) Мэдээлэл нь нийтлэг зорилготой санхүүгийн тайланд биш, харин тусгай зорилготой санхүүгийн тайланд илүү тохирох шинж төрөлтэй байдаг.

ДҮ16. Мөнгөөр хүлээн авсан гадаад тусламжийг Мөнгөн орлого, зарлагын тайланд хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Хөгжиж буй эдийн засаг дахь улсын секторын тайлагнагч олон байгууллагуудын хувьд мөнгөн хэлбэрээр хүлээн авсан гадаад тусламжийн дүн нь мөнгөн орлого, зарлагын тайланд тусдаа толилуулахыг батлан илэрхийлэх магадлалтай гэдгийг тайлбарлахын тулд уг Мөнгөн суурьт УСНББОУС (2017)-д 1.3.18-р параграфыг шинээр нэмсэн.

#### **Гуравдагч талын төлбөр**

ДҮ17. Гуравдагч талын төлбөрийг мөнгөн орлого, зарлагын тайланд тусдаа багана байдлаар толилуулах шалтгаан үндэслэл нь үндсэндээ тодорхой гэж үздэг. Өөрөөр хэлбэл, бараа, үйлчилгээний худалдан авалтад зориулан уг хүлээн авагч байгууллагад олгосон, эсвэл тэрхүү хүлээн авагчийн сонгосон тэдгээр бараа, үйлчилгээний нийлүүлэгчид шууд төлсөн эсэхээс үл хамааран аливаа тайлант үеийн туршид байгууллагын үйл ажиллагааг дэмжихийн тулд мөнгөн нөөцөөр хангах хэлцлийн хэлбэр нь түүнийг мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнах эсэхийг тодорхойлохгүй гэдгийг ханган магадлах явдал юм. Гэвч гуравдагч талын төлбөр нь гадаадын болон бусад тусламжийн тодорхойлолтыг хангах бараа, үйлчилгээний төлбөрөөс ихэвчлэн бүрдэх магадлалтай байдаг.

ДҮ18. Дээр дурдсан гуравдагч талын төлбөр хэлбэрийн гадаад тусламжийн талаархи мэдээллийн тодруулгын шаардлагуудыг биелүүлэхэд хэрэгцээтэй мэдээлэлд хандан нэвтрэх хязгаарлагдмал байдал, түүнчлэн үүний зайлшгүй үр дүн болох бүрэн бус мэдээллийн боломжит буруу тайлбарлалтын талаархи анхаарах зүйлс нь гуравдагч талын төлбөрийн бусад ангиллуудад бас хамаарна.

ДҮ19. Энэхүү Мөнгөн суурьт УСНББОУС (2017) нь гуравдагч талын хийсэн төлбөрийн талаархи мэдээллийн тодруулгын шаардлагуудыг Нэгдүгээр хэсгээс хасаж, сайшаан дэмжсэн тодруулга байдлаар Хоёрдугаар хэсэгт буцаан тусган оруулсан. Энэ нь олон сонгогч иргэдийн санаа зовж буй асуудалд хариулт өгөх бөгөөд тус УСНББОУС-ыг мөрдөхөд тулгарч буй гол саад бэрхшээлийг даван туулах юм.

ДҮ20. Зарим улс оронд, “төрийн сангийн нэг данс” гэж ихэвчлэн нэрлэдэг, төвлөрсөн төрийн сангийн чиг үүргээр дамжуулан засгийн газар нь өөрийн бие даасан хэлтэс газрууд болон бусад байгууллагуудын зарлагыг удирддаг. “Төрийн сангийн нэг данс”-ны ийм зохицуулалтын дагуу засгийн газрын хэлтэс газар болон засгийн газрын бусад байгууллагын өмнөөс тайлагнагч байгууллага буюу төв агентлагийн төлсөн дүнг мөн гуравдагч талын төлбөр байдлаар ангилахаар Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-д заасан. Бие даасан хэлтэс газрууд болон байгууллагууд нь зарцуулах зөвшөөрөл тэдэнд олгогдсон мөнгийг байршуулах банкны тусдаа дансгүй боловч тэрхүү мөнгийг ашиглан зарцуулж чадах ба өгөөж хүртдэг гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс тэд мөнгөн орлого, зарлага болон бэлэн боломжтой байгаа мөнгөний үлдэгдлийг хянадаг. Ийм зохицуулалт нь гуравдагч талын төлбөр биш гэсэн УСНББОУСЗ-ийн байр суурийг тусгахын тулд төрийн сангийн нэг дансны хэлцлийн талаархи нэмэлт тайлбарыг энэхүү Мөнгөн суурьт УСНББОУС (2017)-д тусган оруулсан.

**“Эмхлэн цэгцлэлт” – Алдааны засварлалт, гадаад валют, Улсын Үйлдвэрийн Газар, чанарын шинжүүд**

ДҮ21. Энэ Стандартын шаардлагууд нь адилтгах аккруэл УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* (2006 оны 12 дугаар сард гаргаж, 2011 оны 10 дугаар сард хамгийн сүүлд шинэчлэн баяжуулсан) болон УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө* (2008 оны 4 дүгээр сард гаргаж, 2011 оны 10 дугаар сард хамгийн сүүлд шинэчлэн баяжуулсан)-ийн шаардлагуудтай шууд зөрчилдөөгүй гэдгийг ханган магадлахын тулд *Алдааны Засварлалт ба Гадаад Валют*-ыг зохицуулах хэсгүүдэд тодорхойлсон нэр томъёоны тайлбар болон томъёололд зарим жижиг нэмэлт өөрчлөлт оруулсан.

ДҮ22. Одоогийн УСНББОУС 3, УСНББОУС 4 болон уг Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-ыг батлан гаргах үед байсан адилтгах УСНББОУС хоорондоо нэлээд зөрүүтэй юм. Тэдгээр нь зарим тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн өөр аргуудыг, зарим үед нэмэлт тодруулгыг тусгадаг байсан. Энэхүү Мөнгөн суурьт УСНББОУС (2017)-ын эдгээр хэсгүүдийн хянан засварлалт нь уг шинэчлэн баяжуулсан УСНББОУС 3 ба УСНББОУС 4-ийн бүх шаардлагуудыг бүрэн тусгаагүй гэдгийг уншигч нар мэдэж байвал зохино. Яагаад гэвэл, Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-ын шаардлагууд нь түүний мөрдөлтөнд саад учруулна гэсэн ямар нэг мэдээг УСНББОУСЗ хүлээн аваагүй болно. УСНББОУС 3 ба УСНББОУС 4-ийн бүх өөрчлөлтүүдийг тусган оруулахын тулд уг Мөнгөн суурьт УСНББОУС-д нэмэлт өөрчлөлт оруулах нь тэрхүү УСНББОУС-ын мөрдөлтөнд нэмэлт саад бэрхшээл учруулж болох зарим санамсаргүй үр дагавартай байж болно гэж УСНББОУСЗ үзсэн. Тэдгээр хэсгүүдийн илүү томоохон нэмэлт өөрчлөлтүүд нь энэхүү нягтлах шалгалтын хязгаарлагдмал цар хүрээнээс давж гарах тул уг Стандартын ирээдүйн аливаа нягтлах шалгалтаар түүнийг авч үзэж болох юм.

ДҮ23. Эмхлэн цэгцлэх үйл явцын нэг хэсэг болгон энэхүү хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017)-аар дараах зүйлсийг гүйцэтгэсэн:

- (а) *Улсын Үйлдвэрийн Газар* (УҮГ)-ын тодорхойлолт ба тайлбарыг хассан. УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын шинж чанарыг тодорхойлсон. Энэ нь УСНББОУС, “*УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*” (2016 оны 4-р сард гаргасан)-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдтэй нийцдэг;
- (б) Онолын Үзэл Баримтлал дахь тэдгээрийн тайлбарыг илүү сайн тусган илэрхийлэхийн тулд санхүүгийн тайлагналын зорилтууд, нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн чанарын шинжүүдийн тодорхойлолт ба тайлбар, ийм мэдээллийн нийтлэг хязгаарлалтууд, нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг шинэчлэн баяжуулсан;
- (в) Одоо мөрдөж байгаа УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны адилтгах шаардлагуудыг илүү сайн тусгахын тулд энэ Стандартыг мөрдөх хүчин төгөлдөр болсон хугацаа болон шилжилтийн нөхцлүүдийн талаархи шаардлагуудыг хамтад нь авч үзэж, нэмэлт өөрчлөлт оруулсан.

## **Энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн шаардлагуудын үлгэрчилсэн жишээ**

*Энэхүү Хавсралт нь зөвхөн үлгэрчилсэн жишээ бөгөөд тус Стандартын нэг хэсэг болохгүй. Хавсралтын зорилго нь дараах байгууллагуудын хувьд нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу нийтлэг зорилготой санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахад үүнийг хэрхэн мөрдөхийг үлгэрчлэн харуулснаар энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн шаардлагуудын утгыг тодорхой болгоход туслах явдал юм:*

- A**     **“А” үндэсний засгийн газрын санхүүгийн тайлан;**
- B**     **Засгийн газрын “Б” байгууллагын санхүүгийн тайлан, энэ нь банкин дахь өөрийн дансаа хянадаг; ба**
- B**     **Засгийн газрын “В” хэлтсийн санхүүгийн тайлан, “төрийн сангийн нэг данс” гэж ихэвчлэн нэрлэгдэх төвлөрсөн төрийн сангийн чиг үүргээр дамжуулан түүний мөнгөн орлого, зарлагыг удирддаг.**

## ХАВСРАЛТ 1А - “А” ЗАСГИЙН ГАЗАР

### “А” ҮНДЭСНИЙ ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

#### 200Х ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЙЛАН (Зөвхөн орлого хэсэг)

(мянган валютын нэгжээр)	Тод- руулга	200Х Орлого/ (Зарлага)	200Х-1 Орлого/ (Зарлага)
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>			
<i><b>Татвар</b></i>			
		X	X
		X	X
		X	X
		<u>X</u>	<u>X</u>
		X	X
		X	X
<i><b>Хандив, буцалтгүй тусламж ба бусад туслалцаа</b></i>	10	X	X
<i><b>Зээл</b></i>	3		
Авсан зээлийн мөнгөн орлого:			
Арилжааны санхүүгийн байгууллагаас		X	
Хөгжлийн банкууд ба адилтгах байгууллагуудаас		X	
<i><b>Капитал мөнгөн орлого</b></i>			
Үндсэн хөрөнгийн данснаас хасалтын мөнгөн орлого		X	X
Санхүүгийн хэрэглүүрийн данснаас хасалтын мөнгөн орлого		<u>X</u>	<u>X</u>
		<u>X</u>	<u>X</u>
<i><b>Худалдаа арилжааны үйл ажиллагаа</b></i>			
Худалдаа арилжааны үйл ажиллагааны мөнгөн орлого		X	X
<i><b>Бусад мөнгөн орлого</b></i>	4	X	X
<b>Нийт мөнгөн орлого</b>		<u><b>X</b></u>	<u><b>X</b></u>

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

(мянган валютын нэгжээр)	Тод- руулга	200Х Орлого/ (Зарлага)	200Х-1 Орлого/ (Зарлага)
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>			
<i>Үйл ажиллагаа</i>			
Цалин, хөлс ба ажиллагчдын тэтгэмж		(X)	(X)
Хангамжийн болон хэрэглээний зүйлс		<u>(X)</u>	<u>(X)</u>
		(X)	(X)
<i>Шилжүүлэг</i>			
Буцалтгүй тусламж		(X)	(X)
Бусад шилжүүлгийн төлбөр		<u>(X)</u>	<u>(X)</u>
		(X)	(X)
<i>Капитал зарлага</i>			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт/барьж байгуулалт		(X)	(X)
Санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалт		<u>(X)</u>	<u>(X)</u>
		(X)	(X)
<i>Зээл ба хүүний буцаан төлөлт</i>			
Зээлийн буцаан төлөлт		(X)	(X)
Хүүний буцаан төлөлт		<u>(X)</u>	<u>(X)</u>
		(X)	(X)
<i>Бусад төлбөр</i>	5	<u>(X)</u>	<u>(X)</u>
<b>Нийт мөнгөн зарлага</b>		<u>(X)</u>	<u>(X)</u>
<b>Мөнгөний өсөлт/(бууралт)</b>		<b>X</b>	<b>X</b>
<b>Мөнгөний жилийн эхний үлдэгдэл</b>	2	<b>X</b>	<b>X</b>
<b>Мөнгөний өсөлт/(бууралт)</b>		<u><b>X</b></u>	<u><b>X</b></u>
<b>Мөнгөний жилийн эцсийн үлдэгдэл</b>	2	<u><b>X</b></u>	<u><b>X</b></u>

**ТӨСӨВ БА ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮНГҮҮДИЙН ЗЭРЭГЦҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**“А” Засгийн газрын 200X оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жил**

**Мөнгөн сууриар баталсан төсөв  
(Чиг үүргээр хийсэн зарлагын ангилал)**

(мянган валютын нэгжээр)		Гүйцэтгэлийн дүн	Тодотгосон төсөв	Анхны төсөв	Тодотгосон төсөв ба гүйцэтгэл- ийн хоорондох зөрүү*
<b>МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>ОРЛОГЫН</b>				
	Татвар	X	X	X	X
	Буцалтгүй тусламж ба туслалцааны хэлцэл				
	Зээлийн орлого	X	X	X	X
	Үндсэн хөрөнгө данснаас хасалтын орлого	X	X	X	X
	Санхүүгийн хэрэглүүрийн данснаас хасалтын орлого	X	X	X	X
	Худалдааны үйл ажиллагаа	X	X	X	X
	Бусад мөнгөн орлого	X	X	X	X
	<b>Нийт мөнгөн орлогын дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>ЗАРЛАГЫН</b>				
	Эрүүл мэнд	(X)	(X)	(X)	(X)
	Боловсрол	(X)	(X)	(X)	(X)
	Нийтийн хэв журам/аюулгүй байдал	(X)	(X)	(X)	(X)
	Нийгмийн хамгаалал	(X)	(X)	(X)	(X)
	Батлан хамгаалах	(X)	(X)	(X)	(X)
	Орон сууц, нийтийн аж ахуй	(X)	(X)	(X)	(X)
	Амралт зугаалга, соёл, шашин	(X)	(X)	(X)	(X)
	Эдийн засаг	(X)	(X)	(X)	(X)
	Байгаль орчны хамгаалал	(X)	(X)	(X)	(X)
	Төрийн ерөнхий үйлчилгээ	(X)	(X)	(X)	(X)
	<b>Нийт мөнгөн зарлагын дүн</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
<b>ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

\* “...Зөрүү” гэсэн багана заавал байх албагүй юм. Гэвч гүйцэтгэл ба анхны төсвийн, эсвэл тодотгосон төсвийн аль тохиромжтойг тодорхой заасан зэрэгцүүлэлтийг тусган оруулж болох юм.



## НЭМЭЛТ САНХҮҮГИЙН ТАЙЛАН (СОНГОЛТООР)

Мөнгөн орлого, зарлагын тайланд тусгасан дүнгүүдийн талаархи дэлгэрэнгүй мэдээллээр хангах тухайлбал, сангийн гол бүлгүүдээр мэдээллийг тодруулах, эсвэл зарлагыг гол чиг үүрэг буюу хөтөлбөрөөр тодруулах, эсвэл зээлийн эх үүсвэрийн дэлгэрэнгүй мэдээллээр хангахын тулд нэмэлт санхүүгийн тайланг бэлтгэж болно. Мөн төсөвлөсөн дүнгүүдийг харуулах баганыг тусган оруулж болох юм.

## САНГИЙН АНГИЛЛААР ХАРУУЛСАН МӨНГӨН ОРЛОГЫН ТАЙЛАН

(мянган валютын нэгжээр)	200X Мөнгөн орлого	200X-1 Мөнгөн орлого
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>		
Нэгтгэсэн сангууд	X	X
Тусгай сангууд	X	X
Худалдааны сангууд	X	X
Зээл	X	X
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>X</b>	<b>X</b>

## ЗЭЭЛИЙН ОРЛОГО

(мянган валютын нэгжээр)	Тод- руулга	200X Мөнгөн орлого	200X-1 Мөнгөн орлого
<b>ЗЭЭЛ</b>			
Дотоодын арилжааны санхүүгийн байгууллага		X	X
Гадаадын арилжааны санхүүгийн байгууллага		X	X
Хөгжлийн банкууд ба адилтгах зээлдүүлэгч агентлагууд		X	X
<b>Нийт зээлийн дүн</b>	3	<b>X</b>	<b>X</b>

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨТӨЛБӨР/ҮЙЛ АЖИЛЛАГАА/ЧИГ ҮҮРГЭЭР  
ХАРУУЛСАН МӨНГӨН ЗАРЛАГЫН ТАЙЛАН**

(мянган валютын нэгжээр)	<b>200Х Мөнгөн зарлага</b>	<b>200Х-1 Мөнгөн зарлага</b>
<b>ЗАРЛАГА-Үйл ажиллагааны данс</b>		
Боловсрол	Х	Х
Эрүүл мэнд	Х	Х
Нийгмийн хамгаалал	Х	Х
Батлан хамгаалах	Х	Х
Нийгмийн хэв журам, аюулгүй байдал	Х	Х
Амралт зугаалга, соёл, шашин	Х	Х
Эдийн засаг	Х	Х
Байгаль орчны хамгаалал	Х	Х
Төрийн ерөнхий үйлчилгээ	Х	Х
<b>Нийт зарлагын дүн</b>	<b>Х</b>	<b>Х</b>
<b>ЗАРЛАГА-Капитал данс</b>		
Боловсрол	Х	Х
Эрүүл мэнд	Х	Х
Нийгмийн хамгаалал ба халамж	Х	Х
Батлан хамгаалах	Х	Х
Нийгмийн хэв журам, аюулгүй байдал	Х	Х
Амралт зугаалга, соёл, шашин	Х	Х
Байгаль орчны хамгаалал	Х	Х
Төрийн ерөнхий үйлчилгээ	Х	Х
<b>Нийт зарлагын дүн</b>	<b>Х</b>	<b>Х</b>
<b>Үйл ажиллагааны болон капитал дансдын нийт дүн</b>	<b>Х</b>	<b>Х</b>

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГА—НИЙТ ЗАСГИЙН ГАЗРЫН ТҮВШИН

### Санхүүгийн тайлангийн тэмдэглэл

#### 1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого

##### Бэлтгэсэн суурь

Санхүүгийн тайланг Мөнгөн суурьт УСНББОУС, “Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал”-ын дагуу бэлтгэсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тухайн тайлант үеийн туршид тууштай мөрдсөн.

##### Тайлагнагч байгууллага

Санхүүгийн тайланг “А” улсын үндэсний засгийн газрын хувьд бэлтгэсэн. Тус санхүүгийн тайлан нь холбогдох хууль тогтоомж (Төрийн санхүүгийн хууль 20XX)-д тусгайлан заасанчлан, уг тайлагнагч байгууллагад хамаарна:

Засгийн газрын үйл ажиллагаа нь сонгогч иргэдэд болон тэдний эрх ашгийн өмнөөс үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, нийгмийн хамгаалал, орон сууц, амралт зугаалга, соёл, төрийн ерөнхий үйлчилгээ, эдийн засгийн менежментийн үйлчилгээнээс бүрддэг. [Засгийн газрын түвшин, улс орон ба үзүүлсэн үйлчилгээний шинж төрлийг тодорхойлох.]

Санхүүгийн тайланд хамруулан тусгасан томоохон байгууллагууд болон тэдний үйл ажиллагаа явуулдаг секторын жагсаалтыг энэхүү санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 7-д харуулсан.

##### Толилуулгын валют

Толилуулгын валют нь (А улсын мөнгөн тэмдэгт) юм.

#### 2. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө нь бэлэн мөнгө, харилцах данс, мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бүрддэг. Харилцах данс ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь банкин дахь дансдын үлдэгдэл болон мөнгөний зах зээлийн богино хугацаат хэрэглүүрт хийсэн хөрөнгө оруулалтаас бүрдэнэ.

Мөнгөн орлого, зарлагын тайланд тусгасан мөнгөн хөрөнгө нь дараах дүнгүүдээс бүрдэж байна:

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
Бэлэн мөнгө болон банкин дахь дансдын үлдэгдэл	X	X
Богино хугацаат хөрөнгө оруулалт	X	X
	<u>X</u>	<u>X</u>

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Дээрх дүнд тусгасан Х валютыг “ХХ” Олон улсын агентлагаас олгосон бөгөөд авто замын дэд бүтцийн барилгын ажилд ашиглах зориулалтаар хязгаарлагдсан болно.

### 3. Зээл

Зээл нь арилжааны банк, адилтгах арилжааны санхүүгийн байгууллага, хөгжлийн банк болон адилтгах тусламжийн агентлагуудаас авсан мөнгөн орлогын гүйлгээнээс бүрддэг.

### 4. Бусад мөнгөн орлого

Бусад мөнгөн орлогод хураамж, торгууль, алданги болон бусад төрөл бүрийн орлогыг тусгасан.

### 5. Бусад зарлага

Бусад зарлагад ногдол ашиг, олгосон хуваарилалтууд, шүүхийн зарга маргааны барагдуулалтын төлбөр болон бусад төрөл бүрийн төлбөрийг тусгасан.

### 6. Зарцуулаагүй зээлийн хэрэгсэл

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
<b>Зарцуулаагүй зээлийн хэрэгслийн хөдөлгөөн</b>		
0X оны 01 дүгээр сарын 01 дэх зарцуулаагүй зээлийн хэрэгсэл	X	X
Нэмэлт зээлийн хэрэгсэл	X	X
Боломжит нийт дүн	X	X
Зарцуулсан дүн	(X)	(X)
Хаагдсан/хүчингүй болгосон хэрэгсэл	(X)	(X)
0X оны 12 дугаар сарын 31 дэх зарцуулаагүй зээлийн хэрэгсэл	X	X

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
<b>Зарцуулаагүй зээлийн хэрэгсэл</b>		
Арилжааны санхүүгийн байгууллага	X	X
Хөгжлийн банк болон адилтгах тусламжийн агентлагууд	X	X
Зарцуулаагүй зээлийн хэрэгслийн нийт дүн	X	X

### 7. Томоохон байгууллагууд

#### Байгууллага-200X

“А” Байгууллага  
“Б” Байгууллага  
“В” Байгууллага  
“Г” Байгууллага

#### Байгууллага-200X-1

“А” Байгууллага  
“Б” Байгууллага  
“В” Байгууллага  
“Г” Байгууллага

**8. Зөвшөөрсөн өдөр**

“А” улсын Төрийн сангийн дарга Ноён ҮҮ нь уг санхүүгийн тайланг хэвлэн нийтлэхийг 200Х+1 оны ...-р сарын ХХ өдөр зөвшөөрсөн.

**9. Батлагдсан анхны ба тодотгосон төсөв, гүйцэтгэлийн болон төсвийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт**

Уг батлагдсан төсвийг тухайн санхүүгийн тайланд мөрдсөнтэй ижил нягтлан бодох бүртгэлийн сууриар (мөнгөн суурь), ижил ангиллын сууриар, мөн ижил тайлант хугацааны (200Х оны 01-р сарын 01-нээс 200Х оны 12-р сарын 31-ний) хувьд бэлтгэсэн. Энэ нь нэгтгэсэн санхүүгийн тайланд хамруулсантай ижил байгууллагуудыг агулдаг бөгөөд тэдгээр байгууллагуудыг дээрх Тэмдэглэл 7-д дурдсан.

Анхны төсвийг (огноо)-ны хууль тогтоох ажиллагаагаар баталсан бөгөөд Хойд бүс нутагт (огноо)-нд болсон газар хөдлөлтийн улмаас (огноо)-ны хууль тогтоох ажиллагаагаар гамшгийг арилгахад зориулж ХХХ-ийн нэмэлт төсвийн хуваарилалтыг баталсан. Анхны төсвийн зорилтууд ба бодлого, түүнчлэн дараагийн хянан засварлалтыг тухайн санхүүгийн тайлангийн хамт гаргасан Үйл ажиллагааны тойм болон Төсвийн үр дүнгийн тайланд илүү дэлгэрэнгүй тайлбарласан.

Газар хөдлөлтийн хариу болгон хууль тогтоох ажиллагаагаар баталсан түвшнээс зарлага нь давсаны улмаас Эрүүл мэндийн чиг үүргийн хувьд гүйцэтгэлийн зарлага нь тодотгосон төсвөөс 15 хувиар (анхны төсвөөс 25 хувиар) хэтэрсэн. Өөр материаллаг зөрүү байгаагүй.

**Тодруулга 9-ийн хувилбар – Төсөв ба санхүүгийн тайланг өөр өөр сууриар бэлтгэдэг тохиолдолд**

**9. Батлагдсан анхны ба тодотгосон төсөв, гүйцэтгэлийн болон төсвийн дүнгүүдийн зэрэгцүүлэлт**

Төсвийг чиг үүргээр ангилж, тохируулсан мөнгөн сууриар баталдаг. Батлагдсан төсөв нь 200Х оны 01-р сарын 01-нээс 200Х оны 12-р сарын 31-ний төсвийн хугацааг хамрах бөгөөд засгийн газрын үндсэн секторын хүрээн дэх бүх байгууллагуудыг агуулсан байдаг. Засгийн газрын үндсэн секторт засгийн газрын бүх хэлтэс газрууд хамаарах бөгөөд томоохон хэлтэс газруудыг дээрх Тэмдэглэл 7-д дурдсан, байгууллагуудын жагсаалтанд тусган оруулсан.

Анхны төсвийг (огноо)-ны хууль тогтоох ажиллагаагаар баталсан бөгөөд Хойд бүс нутагт (огноо)-нд болсон газар хөдлөлтийн улмаас (огноо)-ны хууль тогтоох ажиллагаагаар гамшгийг арилгахад зориулж ХХХ-ийн нэмэлт төсвийн хуваарилалтыг баталсан. Анхны төсвийн зорилтууд ба бодлого, түүнчлэн дараагийн хянан засварлалтыг тухайн санхүүгийн тайлангийн хамт гаргасан Үйл ажиллагааны тойм болон Төсвийн үр дүнгийн тайланд илүү дэлгэрэнгүй тайлбарласан.

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Газар хөдлөлтийн хариу болгон хууль тогтоох ажиллагаагаар баталсан түвшнээс зарлага нь давсаны улмаас Эрүүл мэндийн чиг үүргийн хувьд гүйцэтгэлийн зарлага нь тодотгосон төсвөөс 15 хувиар (анхны төсвөөс 25 хувиар) хэтэрсэн. Батлагдсан тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн хооронд өөр материаллаг зөрүү байгаагүй.

Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн сууриуд өөр байдаг. Зардлын шинж төрөлд үндэслэсэн ангиллыг ашиглан тус засгийн газрын санхүүгийн тайланг мөнгөн сууриар бэлтгэдэг. Тус санхүүгийн тайлан нь 20XX оны 01-р сарын 01-нээс 20XX оны 12-р сарын 31-ний төсвийн хугацааны хувьд хяналтанд буй бүх байгууллагуудыг, үүн дотроо улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудыг хамруулсан. Харин төсвийг чиг үүргээр ангилж, тохируулсан мөнгөн сууриар баталдаг ба засгийн газрын үндсэн секторыг зөвхөн хамрах бөгөөд үүнд улсын секторын худалдаа арилжааны байгууллагууд, засгийн газрын зах зээлийн бус бусад зарим байгууллагууд болон үйл ажиллагааг тусгадаггүй.

Тохируулсан мөнгөн суурьтай нийцүүлэхийн тулд уг мөнгөн орлого, зарлагын тайлан дахь дүнгүүдийг тохируулсан бөгөөд батлагдсан, тодотгосон төсөвтэй ижил суурьтай болгох үүднээс чиг үүргийн ангиллаар дахин ангилсан болно. Түүнчлэн, гүйцэтгэлийн дүнгүүдийг тэрхүү батлагдсан, тодотгосон төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлэхийн тулд одоо үргэлжилж буй төсвийн хуваарилалттай холбоотой цаг хугацааны зөрүү болон хамрагдах байгууллагуудын (улсын секторын худалдаа арилжааны байгууллагууд ба бусад байгууллагуудын) зөрүүтэй байдлын хувьд уг мөнгөн орлого, зарлагын тайлан дахь дүнгүүдэд тохируулга хийсэн.

20XX оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайланд толилуулсан гүйцэтгэлийн орлого, гүйцэтгэлийн зарлага болон мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнасан нийт мөнгөн орлого, нийт мөнгөн зарлагын хоорондох тохируулгыг доор харуулав.

	<b>Нийт орлого</b>	<b>Нийт зарлага</b>
Төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлэлтийн тайланд толилуулсан зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн	<b>X</b>	<b>X</b>
Суурийн зөрүү	X	X
Цаг хугацааны зөрүү	-	-
Байгууллагын зөрүү	X	X
Нийт мөнгөн орлого	<b>X</b>	
Нийт мөнгөн зарлага		<b>X</b>

Санхүүгийн тайлан болон төсвийн баримт бичгийг нэг ижил тайлант хугацааны хувьд бэлтгэсэн. Гэвч байгууллагын зөрүүтэй байна: төсвийг засгийн газрын үндсэн секторын хувьд бэлтгэдэг, харин санхүүгийн тайлан нь тухайн засгийн газрын хяналтанд буй бүх байгууллагуудыг агуулсан байдаг. Мөн суурийн зөрүүтэй байдаг: төсвийг тохируулсан мөнгөн сууриар, санхүүгийн тайланг мөнгөн сууриар бэлтгэдэг.

Энэхүү тохируулгыг Төсөв ба Гүйцэтгэлийн Дүнгүүдийн Зэрэгцүүлэлтийн Тайланд эсвэл тэмдэглэл тодруулгад тусгаж болно.

**10. Хандив, буцалтгүй тусламж ба бусад туслалцаа**

Тухайн тайлант үеийн мөнгөн орлого нь олон талт ба хоёр талт бие даасан донор агентлагууд болон төрийн бус байгууллагуудаас өгсөн хандив, буцалтгүй тусламж, бусад туслалцаа, түүнчлэн ийм байгууллагуудаас бүрдүүлсэн хамтын санхүүжилтийн хэрэгсэл болон хүмүүнлэгийн байгууллага, компани, хувь хүмүүсээс авсан хандивыг тусган агуулсан байдаг.

Хандив, буцалтгүй тусламж, бусад туслалцааны (XXX) дүнд тухайн тайлант үеийн туршид зээлийн мөнгөн орлого хэлбэрээр хүлээн авсан туслалцааг хамруулаагүй. Тайлант үеийн туршид зээл хэлбэрээр хүлээн авсан аливаа туслалцааны мөнгөн орлогыг тус Мөнгөн орлого, зарлагын тайланд тусдаа мөрийн зүйл байдлаар толилуулсан зээлийн дүнд тусган оруулсан.

## ХАВСРАЛТ 1Б - ЗАСГИЙН ГАЗРЫН “Б” БАЙГУУЛЛАГА

(ЭНЭ БАЙГУУЛЛАГА НЬ БАНКИН ДАХЬ ӨӨРИЙН ДАНСЫГ ХЯНАДАГ.)  
 200Х ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН  
 ЖИЛИЙН МӨНГӨН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЙЛАН

(мянган валютын нэгжээр)	Тод- руулга	200Х Орлого/(Зарлага)	200Х-1 Орлого/(Зарлага)
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>			
Зөвшөөрөгдсөн хуваарилалт		X	X
Бусад мөнгөн орлого		X	X
<b>Нийт мөнгөн орлого</b>		<b>X</b>	<b>X</b>
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>			
Цалин, хөлс ба ажиллагчдын тэтгэмж		(X)	(X)
Түрээс		(X)	(X)
Капитал зарлага		(X)	(X)
Шилжүүлэг	3	(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлага</b>		<b>(X)</b>	<b>(X)</b>
<b>Мөнгөний өсөлт/(бууралт)</b>		<b>X</b>	<b>X</b>
<b>Мөнгөний жилийн эхний үлдэгдэл</b>	2	<b>X</b>	<b>X</b>
<b>Мөнгөний өсөлт/(бууралт)</b>		<b>X</b>	<b>X</b>
<b>Мөнгөний жилийн эцсийн үлдэгдэл</b>	2	<b>X</b>	<b>X</b>



## НЭМЭЛТ САНХҮҮГИЙН ТАЙЛАН (СОНГОЛТООР)

Тухайлбал, төсвийн мэдээллийг хэрэв боломжтой бол сангийн гол бүлгүүдээр тодруулах, эсвэл зарлагыг гол чиг үүргээр харуулахын тулд нэмэлт санхүүгийн тайланг бэлтгэж болно. Чиг үүргээр ангилсан тайлангийн жишээг доор харуулав.

### ЧИГ ҮҮРГЭЭР ХАРУУЛСАН ЗАРЛАГЫН ТАЙЛАН

(мянган валютын нэгжээр)	Тодруулга	200X Зарлага	200X-1 Зарлага
<b>ЗАРЛАГА</b>			
Хөтөлбөр I		(X)	(X)
Хөтөлбөр II		(X)	(X)
Хөтөлбөр III		(X)	(X)
Хөтөлбөр IV		(X)	(X)
Бусад зарлага		(X)	(X)
<b>Нийт зарлага</b>		<b>(X)</b>	<b>(X)</b>

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

### 1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого

#### Бэлтгэсэн суурь

Санхүүгийн тайланг Мөнгөн суурьт УСНББОУС, “Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал”-ын дагуу бэлтгэсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тухайн тайлант үеийн туршид тууштай мөрдсөн.

#### Тайлагнагч байгууллага

Санхүүгийн тайланг улсын секторын байгууллагын (Засгийн газрын “Б” байгууллагын) хувьд бэлтгэсэн. Тус санхүүгийн тайлан нь холбогдох хууль тогтоомж (Төрийн санхүүгийн хууль 20XX)-д тусгайлан заасанчлан, уг тайлагнагч байгууллагад хамаарна.

Засгийн газрын “Б” байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь иргэд сонгогчдод [төрлийг бичих] үйлчилгээ үзүүлэх явдал юм. Байгууллага нь банкин дахь өөрийн дансыг хянадаг.

#### Толилуулгын валют

Толилуулгын валют нь (А улсын мөнгөн тэмдэгт) юм.

### 2. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө нь бэлэн мөнгө, харилцах данс, мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бүрддэг. Харилцах данс ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь банкин дахь дансдын үлдэгдэл болон мөнгөний зах зээлийн богино хугацаат хэрэглүүрт хийсэн хөрөнгө оруулалтаас бүрдэнэ.

Байгууллагад төсөвлөн хуваарилсан дүнг уг байгууллагын банкин дахь дансанд байршуулдаг. Бүх зээлийг төв санхүүгийн байгууллага нь хариуцдаг.

Арилжааны ажил гүйлгээний мөнгөн орлогыг тухайн байгууллагын хянадаг худалдааны сангийн дансанд байршуулдаг. Нэгтгэсэн орлогод тэдгээрийг жилийн эцэст шилжүүлдэг.

Мөнгөн орлого, зарлагын тайланд тусгасан мөнгөн хөрөнгө нь дараах дүнгүүдээс бүрдэж байна:

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
Бэлэн мөнгө болон банкин дахь дансдын үлдэгдэл	X	X
Богино хугацаат хөрөнгө оруулалт	X	X
	<u>X</u>	<u>X</u>

3. **Шилжүүлэг**

Тухайн байгууллагын үйл ажиллагааны үүрэг хариуцлага ба бүрэн эрхийн дагуу шалгуур хангасан хүлээн авагчдад дүнг шилжүүлдэг.

4. **Томоохон байгууллагууд**

**Байгууллага-200Х**

“Х” Байгууллага

“У” Байгууллага

**Байгууллага-200Х-1**

“Х” Байгууллага

“Х” Байгууллага

5. **Зөвшөөрсөн өдөр**

XXXXX-ын Сайд ноён ҮҮ нь “Б” байгууллагын санхүүгийн тайланг нийтэд гаргахыг 200Х+1 оны ...-р сарын ХХ өдөр зөвшөөрсөн.

## ХАВСРАЛТ 1В - ЗАСГИЙН ГАЗРЫН “В” ГАЗАР

(ЗАСГИЙН ГАЗАР НЬ ТӨВЛӨРСӨН НЭГ ДАНСНЫ СИСТЕМИЙГ АШИГЛАДАГ)

“В” ГАЗРЫН 200Х ОНЫ 12-Р САРЫН 31-НЭЭР ДУУСГАВАР БОЛСОН  
ЖИЛИЙН МӨНГӨН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЙЛАН

(мянган валютын нэгжээр)	Тод- руулга	200Х Орлого/(Зарлага)	200Х-1 Орлого/(Зарлага)
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>			
Хуваарилалт/Төсвийн хуваарилалт	2	X	X
Бусад мөнгөн орлого		X	X
<b>Нийт мөнгөн орлого</b>		<b>X</b>	<b>X</b>
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>			
Цалин, хөлс ба ажиллагчдын тэтгэмж		(X)	(X)
Түрээс		(X)	(X)
Капитал зарлага		(X)	(X)
Шилжүүлэг	3	(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлага</b>		<b>(X)</b>	<b>(X)</b>

## НЭМЭЛТ САНХҮҮГИЙН ТАЙЛАН (СОНГОЛТООР)

Тухайлбал, төсвийн мэдээллийг хэрэв боломжтой бол сангийн гол бүлгүүдээр тодруулах, эсвэл зарлагыг гол чиг үүргээр буюу төлбөрөөр харуулахын тулд нэмэлт санхүүгийн тайланг бэлтгэж болно. Чиг үүргээр ангилсан тайлангийн жишээг доор харуулав.

### ЧИГ ҮҮРГЭЭР ХАРУУЛСАН ЗАРЛАГЫН ТАЙЛАН

(мянган валютын нэгжээр)	Тодруулга	200X Зарлага	200X-1 Зарлага
<b>ЗАРЛАГА</b>			
Хөтөлбөр I		(X)	(X)
Хөтөлбөр II		(X)	(X)
Хөтөлбөр III		(X)	(X)
Хөтөлбөр IV		(X)	(X)
Бусад зарлага		(X)	(X)
<b>Нийт зарлага</b>		<u>(X)</u>	<u>(X)</u>

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ**

### **1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

#### **Бэлтгэсэн суурь**

Санхүүгийн тайланг Мөнгөн суурьт УСНББОУС, “*Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал*”-ын дагуу бэлтгэсэн.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тухайн тайлант үеийн туршид тууштай мөрдсөн.

#### **Тайлагнагч байгууллага**

Санхүүгийн тайланг улсын секторын байгууллага болох Засгийн газрын “В” газрын хувьд бэлтгэсэн. Тус санхүүгийн тайлан нь холбогдох хууль тогтоомж (Төрийн санхүүгийн хууль 20XX)-д тусгайлан заасанчлан, уг тайлагнагч байгууллагад хамаарна.

Засгийн газрын “В” газрын үндсэн үйл ажиллагаа нь иргэд сонгогчдод [төрлийг бичих] үйлчилгээ үзүүлэх явдал юм.

Засгийн газрын “В” газар нь банкинд өөрийн харилцах данс эзэмшдэггүй. Засгийн газар нь тухайн санхүүгийн жилийн туршид тус газрын мөнгөн орлого, зарлагыг (төлбөрийг) удирдах, төвлөрсөн төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

#### **Толилуулгын валют**

Толилуулгын валют нь (А улсын мөнгөн тэмдэгт) юм.

### **2. “В” газар ашиглахаар түүнд зөвшөөрөгдсөн дүн**

Засгийн газрын “В” газар ашиглахаар түүнд зөвшөөрөгдсөн дүнг Төрийн сангийн газрын удирдан зохицуулдаг уг төвлөрсөн дансаар дамжуулан тус Газрын өмнөөс захиран зарцуулдаг. Зохих баримтжуулалт ба зөвшөөрлийг танилцуулж, дэмжигдсэн тохиолдолд тус Газрын хүсэлтээр түүний өмнөөс дүнг зарцуулдаг. Бүх зээлийг төв санхүүгийн байгууллага нь хариуцдаг.

“В” газар ашиглахаар түүнд зөвшөөрөгдсөн боловч тухайн жилийн эцэст зарцуулаагүй дүнг нэгдсэн орлогод шилжүүлдэг.

### **3. Шилжүүлэг**

“В” газрын үйл ажиллагааны үүрэг хариуцлага ба бүрэн эрхийн дагуу шалгуур хангасан хүлээн авагчдад дүнг шилжүүлдэг.

### **4. Зөвшөөрсөн өдөр**

XXXXX-ын Сайд ноён ҮҮ нь Засгийн газрын “В” газрын санхүүгийн тайланг нийтэд гаргахыг 200X+1 оны ...-р сарын XX өдөр зөвшөөрсөн.

## **ХОЁРДУГААР ХЭСЭГ: НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ—САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА**

*Стандартын энэ хэсгийг заавал дагаж мөрдөх албагүй юм. Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн сууриас санхүүгийн тайлагналын аккруэл суурьт болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжиж буй байгууллагуудыг дэмжихийн тулд үүнийг бэлтгэсэн. Нягтлан бодох бүртгэлийн мөнгө суурьт тайлагналын хувьд сайшаан дэмжсэн нэмэлт тодруулгуудыг энд тусгасан. Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурьт тайлагналын шаардлагуудыг тогтоосон энэ Стандартын Нэгдүгээр хэсэгтэй үүнийг хамт унших хэрэгтэй. Ташуу хэлбэрээр бичсэн уг сайшаан дэмжсэн тодруулгуудыг тус Стандартын энэ хэсэгт энгийн хэлбэрээр бичсэн тайлбар параграфуудын хүрээнд уншвал зохино.*

*Тайлагнагч байгууллагууд нь аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд чиглэсэн өөрсдийн арга замыг төлөвлөн тогтоох ба тэрхүү баталсан шилжилтийн арга замын дагуу УСНББОУС-уудыг мөрдөхөд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх үйл явцыг эхлүүлэн явуулах хэрэгтэй.*

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ХОЁРДУГААР ХЭСЭГ: САЙШААН ДЭМЖСЭН НЭМЭЛТ ТОДРУУЛГА

### 2.1 Сайшаан дэмжсэн нэмэлт тодруулга

#### Тодорхойлолт

2.1.1 *Дараах нэр томъёог Стандартын энэ хэсэгт доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:*

Аккруэл суурь гэдэг нь ажил гүйлгээ ба үйл явдлыг тэдгээрийн гарч тохиолдсон үед (зөвхөн мөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийг хүлээн авсан буюу төлсөн үед биш) хүлээн зөвшөөрөх нягтлан бодох бүртгэлийн суурь юм. Иймээс ажил гүйлгээ ба үйл явдлыг тэдгээрийн хамаарах тайлант үед нягтлан бодох бүртгэлд бүртгэж, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Аккруэл нягтлан бодох бүртгэлийн дагуу хүлээн зөвшөөрдөг элементүүд нь хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал юм.

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд байгууллага хяналтандаа оруулсан бөгөөд түүнээс уг байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болохоор хүлээгдэж буй нөөц юм.

Зээлийн өртөг гэдэг нь мөнгө санг зээлдэн авахтай холбоотойгоор байгууллагын гаргах хүүний болон бусад зардал юм.

Хаалтын ханш гэдэг нь тайлант үеийн эцэс дэх спот ханш юм.

Эздэд олгосон хуваарилалт гэдэг нь тухайн байгууллага өөрийн бүх буюу зарим эздэд хөрөнгө оруулалтын өгөөж эсвэл хөрөнгө оруулалтын буцаалт хэлбэрээр хуваарилсан ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи юм.

Зардал гэдэг нь эздэд олгосон хуваарилалттай холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчийг багасгах үр дүн бүхий хөрөнгийн зарлагын гүйлгээ буюу хорогдон багасалт, эсвэл өр төлбөр үүсэлт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралт юм.

Өр төлбөр гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн уг байгууллагын одоогийн үүрэг бөгөөд түүнийг барагдуулсанаар эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөц тухайн байгууллагаас гарахаар хүлээгдэж байдаг.

Орлого гэдэг нь эздээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээ юм.

Энэ Стандартын Нэгдүгээр хэсэгт тодорхойлсон нэр томъёог түүнд тодорхойлсонтой ижил утгаар Стандартын энэ хэсэгт хэрэглэсэн.



### **Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи**

2.1.2 Хөрөнгө, үүн дотроо мөнгө болон бусад нөөц нь өөрийнхөө зорилтонд хүрэх арга хэрэгслээр байгууллагыг хангадаг. Байгууллагын зорилтын дагуу бараа, үйлчилгээг нийлүүлэхэд ашигладаг боловч цэвэр мөнгөн орлогын гүйлгээг шууд үүсгэн бий болгодоггүй хөрөнгүүдийг “үйлчилгээний чадавхи агуулсан” гэж ихэвчлэн нэрлэдэг. Цэвэр мөнгөн орлогын гүйлгээг бий болгоход ашигладаг хөрөнгүүдийг “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж агуулсан” гэж ихэвчлэн нэрлэдэг. Хөрөнгийг ашиглаж болох бүх зорилгыг нэгтгэн илэрхийлэхийн тулд энэ Стандартад хөрөнгүүдийн чухал шинж чанаруудыг тодорхойлох үүднээс “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи” гэсэн нэр томъёог ашигласан.

### **Тасралтгүй байх суурь**

2.1.3 *Байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх үедээ тухайн санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага бүхий этгээд нь үйл ажиллагаагаа тасралтгүй байдлаар үргэлжлүүлэн явуулах уг байгууллагын чадвар боломжийг үнэлэхийг дэмжинэ. Ийм үнэлгээг хийх үедээ тухайн санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага бүхий этгээд нь нь тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах уг байгууллагын чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал буюу нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхойгүй байдлыг мэдсэн тохиолдолд тэдгээр тодорхойгүй байдлын талаар тодруулга хийхийг дэмжинэ.*

2.1.4 Тасралтгүй байх төсөөлөл тохиромжтой эсэх тодорхойлолт нь бүхэлдээ засгийн газартай биш, харин тухайн бие даасан байгууллагуудад юуны өмнө хамааралтай байдаг. Бие даасан байгууллагуудын хувьд тасралтгүй байх суурь тохиромжтой эсэхийг үнэлэхдээ, санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага бүхий этгээд нь тасралтгүй байх төсөөлөл тохиромжтой гэж дүгнэх үндэслэлтэй болохын өмнө, дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- (а) Урьдчилан харж болох ирээдүйн талаархи бэлэн боломжтой байгаа бүх мэдээллийг харгалзан үзнэ. Урьдчилан харж болох ирээдүй гэдэг нь уг санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн өдрөөс хойшхи арван хоёр сарын хугацааг хамрах боловч үүгээр хязгаарлагдахгүй; ба
- (б) Одоогийн болон хүлээгдэж буй үр дүн, зохион байгуулалтын нэгжүүдийн хувьд хийгдэх боломжит ба зарласан бүтцийн өөрчлөлт, орлогын тооцоолол буюу засгийн газрын тасралтгүй санхүүжилтийн магадлал, орлох санхүүжилтийн боломжит эх үүсвэрүүд зэрэг янз бүрийн хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байж болно.

2.1.5 Бизнесийн байгууллагуудад хэрэглэдэг төлбөрийн чадвар ба хөрвөх чадварт үндэслэсэн тасралтгүй байдлын нийтлэг сорил нь тааламжгүй байгааг илэрхийлэх боловч тухайн байгууллага ямартаа ч тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэдгийг бусад хүчин зүйлс харуулах тийм нөхцөл байдалтай байж болно. Тухайлбал;

- (а) Засгийн газар тасралтгүй үйл ажиллагаа явуулах эсэхийг үнэлэх үед, хэдийгээр байгууллагуудын мөнгөн зарлага нь нэлээд удаан хугацаанд мөнгөн орлогоос хэтэрсэн байж болох боловч татвар буюу хураамж ногдуулах бүрэн эрхтэй байх нь тэдгээр байгууллагуудыг тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэж үзэхэд хүргэж болох юм; ба
- (б) Бие даасан байгууллагын хувьд, тухайн тайлант үед түүний мөнгөн гүйлгээнд хийсэн үнэлгээ нь тасралтгүй ажиллах төсөөлөл уг байгууллагад тохиромжгүй гэдгийг илэрхийлж болох юм. Гэвч тэрхүү байгууллагын тасралтгүй ажиллагааг хангах олон жилийн санхүүжилтийн хэлцлийг засгийн газартай байгуулсан байж болно.

### **Туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээ**

- 2.1.6 *Бусдын өмнөөс агент байдлаар байгууллагын туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээний үр дүн болох мөнгөн гүйлгээ болон мөнгөний үлдэгдэл нь тухайн байгууллагын хяналтаас ангид байх тохиолдолд тэдгээр мөнгөн гүйлгээ ба мөнгөний үлдэгдлийн дүн, шинж төрлийг тэрхүү байгууллага нь санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт тодруулахыг дэмжинэ.*
- 2.1.7 Бусдын өмнөөс агентын үүрэг гүйцэтгэж буй байгууллагын туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээтэй холбоотой мөнгөн гүйлгээ нь уг тайлагнагч байгууллагын хянадаг банкны дансаар дамждаггүй байж болно. Ийм тохиолдолд байгууллага нь тэрхүү туслалцаа үзүүлсэн мөнгийг өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ ашиглаж чадахгүй буюу түүнээс өөр бусад байдлаар өгөөж хүртэхгүй юм. Байгууллага нь эдгээр мөнгөн гүйлгээг хянадаггүй, иймээс мөнгөн орлого, зарлагын тайланд, эсвэл бэлтгэж болох бусад санхүүгийн тайланд харуулсан мөнгөний нийт дүнд түүнийг оруулахгүй. Гэвч эдгээр ажил гүйлгээний гол төрлөөр харуулсан дүнгийн болон шинж төрлийн тодруулга нь тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээний талаархи ач холбогдолтой мэдээллээр хангах бөгөөд уг байгууллагын үр дүнг үнэлэхэд хамааралтай байх учраас ийм тодруулга хийхийг дэмжинэ.
- 2.1.8 Ийм мөнгөн орлого, зарлагыг тухайн байгууллагын хянадаг банкны харилцах дансаар дамжуулдаг тохиололд тэдгээрийг тус байгууллагын өөрийн мөнгөн гүйлгээ болон үлдэгдэлтэй адил байдлаар авч үзэх бөгөөд мөнгөн орлого, зарлагын тайланд харуулсан нийт дүнд тусган оруулна. Ийм мөнгөн орлого, зарлагыг цэвэр дүнгээр тайлагнахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.13(а) параграфт зөвшөөрсөн байдаг. Дараах мөнгөн орлого, зарлага болон үлдэгдлийн талаархи заавар удирдамжийг доорх 2.1.9-2.1.13-р параграфт заасан:
  - (а) Засгийн газар буюу засгийн газрын байгууллагаас хянаж болох бөгөөд энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн дагуу мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнах; ба
  - (б) Мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл бэлтгэж болох бусад санхүүгийн тайланд тусгахгүй боловч түүний талаар тодруулга хийхийг дэмжсэн, туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээ.

## Орлогын цуглуулалт

- 2.1.9 Улсын секторын байгууллагууд нь засгийн газар, бусад засгийн газрууд буюу засгийн газрын байгууллагуудын өмнөөс мөнгөн хөрөнгийг хянаж, эсвэл мөнгөн орлого, зарлагыг удирддаг байж болно. Жишээлбэл; засгийн газрын Татварын албыг (буюу Орлого хураах агентлагийг) банкинд өөрийн харилцах данстайгаар байгуулж, түүний үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд төсвийн хуваарилалт олгож болох юм. Татварын хууль тогтоомжийн зарим төлөв хандлагын хэрэгжүүлэлт нь тус Албаны үйл ажиллагаанд хамаарах бөгөөд засгийн газрын өмнөөс татвар хураах ажиллагааг агуулсан байж болно.
- 2.1.10 Татварын Алба нь түүнд төсөвлөн хуваарилсан бөгөөд түүний хянадаг банкны дансанд байршуулсан мөнгийг өөрийн үйл ажиллагааны зорилтуудад хүрэхийн тулд бүрэн эрхийн дагуу ашиглан зарцуулж, бусад этгээд тэрхүү мөнгийг ашиглах буюу өгөөж хүртэхээс сэргийлж чадах юм. Ийм тохиолдолд тус Алба нь түүний хэрэглээнд зориулан төсөвлөн хуваарилагдсан мөнгийг хянадаг. Харин татвар хураах өөрийн үйл ажиллагаагаар дамжуулан засгийн газрын өмнөөс тус Албаны цуглуулсан мөнгийг засгийн газрын тусгайлан заасан итгэмжлэлийн санд ихэвчлэн байршуулах буюу Төрийн сан болон адилтгах хэлтэс газрын захиран зарцуулдаг засгийн газрын банкны харилцах дансанд шилжүүлдэг. Энэ тохиолдолд уг цуглуулсан мөнгийг Татварын Албаны зорилтуудын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үүднээс зарцуулах, эсвэл засгийн газар буюу холбогдох эрх бүхий байгууллагын тусгайлсан төсвийн хуваарилалт болон бусад зөвшөөрөлгүйгээр тус Албаны удирдлагын шийдвэрээр өөр бусад байдлаар ашиглаж болохгүй юм. Иймээс уг цуглуулсан мөнгийг Татварын Алба хянахгүй бөгөөд тус Албаны мөнгөн орлого буюу мөнгөний үлдэгдлийн нэг хэсэг болохгүй. Засгийн газрын шийдвэрийн үр дүнд тэрхүү цуглуулсан мөнгөний зарим хэсгийг Татварын Албаны хэрэгцээнд зориулан төсөвлөн хуваарилж эсвэл өөр бусад байдлаар хуваарилж болно. Гэвч энэ нь хяналт үүсэхэд хүргэх уг мөнгөний цуглуулалтын үр дүн биш, харин мөнгө санг тус Татварын Алба зарцуулахыг зөвшөөрсөн засгийн газрын шийдвэрийн үр дүн юм.
- 2.1.11 Нэг засгийн газар, тухайлбал мужийн буюу орон нутгийн засгийн газар нь өөр засгийн газрын (үндэсний засгийн газар гэх мэт) өмнөөс мөнгийг цуглуулдаг бол үүнтэй адилтгах нөхцөл байдал үүсэж болох юм. Ийм тохиолдолд тухайн засгийн газар нь мөнгө цуглуулалтын хувьд бусдын өмнөөс агентын үүргийг гүйцэтгэж байна. Бусдын агент байдлаар ажил гүйлгээг удирдан гүйцэтгэсний үр дүнд бий болсон мөнгийг тухайн цуглуулагч агентын банкны харилцах дансанд ихэвчлэн байршуулдаггүй бөгөөд иймээс уг тайлагнагч байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага буюу мөнгөний үлдэгдлийн нэг хэсгийг бүрдүүлэхгүй.

### “Дамжуулах” мөнгөн гүйлгээ

- 2.1.12 Зарим тохиолдолд өөр байгууллагын агент байдлаар засгийн газар эсвэл засгийн газрын байгууллагын гүйцэтгэдэг орлого цуглуулах үйл

ажиллагааны хувьд хийгдсэн туслалцаа үзүүлэх хэлцлийн дагуу тухайн цуглуулсан мөнгийг эцсийн хүлээн авагчид шилжүүлэхийн өмнө, тэрхүү байгууллагын банкны харилцах дансанд эхлээд байршуулдаг. Ийм ажил гүйлгээний үр дүнд үүсэх мөнгөн гүйлгээг зарим үед “дамжуулах” мөнгөн гүйлгээ гэж нэрлэдэг. Энэ тохиолдолд тухайн байгууллага нь:

- (а) Агент болохын хувьд өөрийн бүрэн эрхийн хүрээнд цуглуулсан мөнгөө ихэвчлэн богино хугацаанд хянадаг бөгөөд гуравдагч талд шилжүүлэхийн өмнө тэрхүү мөнгийг өөрийн банкны харилцах дансанд байршуулдаг;
- (б) Өөр байгууллагад шилжүүлэхээс өмнө, хүү тооцогдох дансанд байршуулсан уг дүнгээс бий болох аливаа хүүнээс ихэвчлэн өгөөж хүртдэг; ба
- (в) Уг цуглуулсан мөнгийг хууль тогтоомжийн шаардлага буюу туслалцаа үзүүлэх хэлцлийн дагуу гуравдагч талд шилжүүлэх үүрэг хүлээдэг.

Туслалцаа үзүүлэх ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн орлогыг уг тайлагнагч байгууллагын хянадаг банкны дансаар дамжуулдаг тохиолдолд тэрхүү цуглуулалтын ажиллагааны үр дүн болох мөнгөн орлого, мөнгөн шилжүүлэг, мөнгөний үлдэгдлийг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.4(а) параграфт заасанчлан, тус байгууллагын мөнгөн орлого, зарлагын тайланд тусгана. Бусад талуудын өмнөөс тухайн байгууллагын туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээнээс үүссэн бөгөөд санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн мөнгөн орлого, зарлагыг цэвэр дүнгээр тайлагнаж болно гэдгийг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.13(а) параграфт тусгайлан заасан.

### **Шилжүүлгийн төлбөр**

2.1.13 Засгийн газрын зорилтууд, хууль тогтоомж буюу бусад бүрэн эрхийн дагуу засгийн газрын байгууллага (хэлтэс газар, агентлаг буюу түүнтэй адилтгах байгууллага)-д төсөвлөн хуваарилсан дүн нь тухайлбал, ажилгүйдлийн тэтгэмж, өндөр насны буюу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, өрхийн хөнгөлөлт, нийгмийн хамгааллын болон нийгмийн бүлгүүдийн бусад тэтгэмжийн төлбөрийн хувьд гуравдагч талуудад шилжүүлэх дүнг агуулсан байж болно. Зарим тохиолдолд ийм төлбөрүүдийг тухайн байгууллагын хянадаг банкны харилцах дансаар дамжуулдаг. Ийм тохиолдолд байгууллага нь тухайн тайлант үеийн хувьд шилжүүлэгт зориулан төсөвлөн хуваарилсан мөнгийг мөнгөн орлого гэж, тэрхүү тайлант үеийн туршид шилжүүлсэн дүнг мөнгөн зарлага гэж, харин ирээдүйн шилжүүлэгт зориулан тайлант үеийн эцэст эзэмшиж буй аливаа дүнг мөнгөний эцсийн үлдэгдлийн нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрнө.

### **Мөнгөн гүйлгээний гол ангиудын тодруулга**

2.1.14 *Байгууллага нь дараах зүйлсийг мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл бусад санхүүгийн тайланд буюу тэдгээр санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулахыг дэмжинэ:*

- (а) *Зарлагын шинж төрөлд эсвэл тухайн байгууллагын хүрээн дэх тэдгээр зарлагын чиг үүргийн аль тохиромжтойд үндэслэсэн ангиллыг ашиглаж, харуулсан нийт мөнгөн зарлагын задаргаа шинжилгээ; ба*
- (б) *Зээлийн мөнгөн орлого. Мөн тухайн зээлийн дүнг цаашид тэдгээрийн төрөл болон эх үүсвэрээр ангилж болно.*

- 2.1.15 2.1.14(а) параграфт сайшаан дэмжсэн дэд ангиллуудыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.12-р параграфын шаардлагуудын дагуу мөнгөн орлого, зарлагын тайланд толилуулж болно. Мөнгөн орлого, зарлагын тайланд ангиллын өөр суурийг хэрэглэдэг тохиолдолд дээрх 2.1.14(а) параграф дахь сайшаан дэмжилтийг тусган илэрхийлэх, илүү дэлгэрэнгүй задалсан нэмэлт тодруулгыг тусдаа тайлан эсвэл тэмдэглэл хэлбэрээр харуулахыг сайшаан дэмжинэ.
- 2.1.16 Зарлага гаргасан гол зорилгыг тодорхойлсноор хариуцлагатай байдлыг сайжруулахын тулд мөнгөн зарлагын зүйлсийг цаашид дэд ангиллуудаар харуулж болно. Тухайн тайлагнагч байгууллагын тодорхой хөтөлбөр, үйл ажиллагаа буюу бусад холбогдох сегментүүдийн өртөг зардал болон өртгийн нөхөлтийг онцлон илэрхийлэхийн тулд эдгээрийг мөн дэд ангиллаар харуулж болно. Байгууллага нь энэхүү мэдээллийг дараах хоёр арга замын наад зах нь аль нэгээр толилуулахыг сайшаан дэмжинэ.
- 2.1.17 Эхний аргыг зарлагын шинж төрлийн арга гэж нэрлэдэг. Мөнгөн орлого, зарлагын тайланд зарлагыг тэдгээрийн шинж төрлийн дагуу (жишээлбэл; түүхий эд материалын худалдан авалт, тээврийн зардал, цалин хөлс) нэгтгэн нийлүүлдэг бөгөөд тухайн байгууллагын хүрээн дэх янз бүрийн чиг үүргээр дахин хуваарилахгүй. Зарлагын шинж төрлийн аргыг ашиглан хийсэн ангиллын жишээг доор харуулав:

	<b>Мөнгөн зарлага</b>
Цалин хөлс	(X)
Тээврийн зардал	(X)
Капитал зарлага	(X)
Зээлийн өртөг	(X)
Бусад	(X)
Нийт зарлага	<u>(X)</u>

- 2.1.18 Чиг үүргийн ангиллын арга гэж нэрлэх хоёр дахь арга нь зарлага гаргасан зорилго буюу хөтөлбөрийн дагуу зарлагыг ангилдаг. Чиг үүргүүд дэх зарлагын ангилал нь санамсаргүй тохиолдлын бөгөөд нэлээд шүүн тунгаалтыг агуулсан байж болох боловч энэхүү толилуулга нь хэрэглэгчдийг илүү их хамааралтай мэдээллээр ихэвчлэн хангадаг. Мөнгөн зарлагын чиг үүргийн ангиллын жишээг доор харуулав:

	<b>Мөнгөн зарлага</b>
Эрүүл мэндийн үйлчилгээ	(X)
Боловсролын үйлчилгээ	(X)
Бусад	(X)
Нийт зарлага	<u>(X)</u>

- 2.1.19 Байгууллагын эрхлэн гүйцэтгэдэг үндсэн чиг үүрэгтэй холбоотой мөнгөн зарлагыг энэхүү аргын дагуу тусад нь харуулдаг. Дээрх жишээнд байгууллага нь эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй байна. Байгууллага нь эдгээр чиг үүрэг тус бүрийн хувьд мөнгөн зарлагын мөрийн зүйлсийг толилуулна.
- 2.1.20 Мөнгөн зарлагыг чиг үүргээр ангилж буй байгууллагууд нь зарлагын шинж төрлөөр, үүн дотроо цалин болон ажиллагчдын бусад тэтгэмжийн хувьд хийсэн төлбөрийн талаархи нэмэлт мэдээлэл тодруулахыг дэмжинэ.
- 2.1.21 Байгууллагын нийт мөнгөн орлого, үүнд: тухайн байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой ангиллын суурийг ашиглан нийт мөнгөн орлогын дэд ангиллыг тусад нь харуулахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.12-р параграфт шаардсан байдаг. Тохиромжтой ангиудаар хийх мөнгөн орлогын дэд ангилал нь тухайн хамаарах дүнгүүдийн хэмжээ, шинж төрөл, чиг үүргээс хамаардаг. Зээлийн мөнгөн орлогын дүнгийн тодруулгаас гадна дараах дэд ангиллууд тохиромжтой байж болно:
- (a) Татварын орлого (татварын төрлүүдээр цаашид дэд ангилж болно);
  - (б) Хураамж, торгууль, алданги болон зөвшөөрлийн орлого;
  - (в) Арилжааны ажил гүйлгээний орлого, үүн дотроо бараа, үйлчилгээний борлуулалт ба хэрэглэгчдийн төлбөр (эдгээрийг арилжааны ажил гүйлгээ гэж ангилдаг тохиолдолд);
  - (г) Гадаадын болон бусад тусламжийн орлогын нийт дүн (үзүүлсэн буцалтгүй тусламж, зээл, бусад тусламжийн дүнгээр, тусламж үзүүлэгчийн гол ангиуд болон олгосон дүнгээр ангилж болно);
  - (д) Бусад буцалтгүй тусламж, шилжүүлэг буюу төсвийн хуваарилалтын орлого (эх үүсвэр болон зориулалтаар ангилж болно);
  - (e) Хүү болон ногдол ашгийн орлого; ба
  - (ж) Бэлэг, хандив болон бусад хэлбэрийн тусламжийн орлого.

### **Холбоотой талуудын тодруулга**

- 2.1.22 *Байгууллага нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт УСНББОУС 20, “Холбоотой Талуудын Тодруулга”-аар шаардсан мэдээллийг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулахыг дэмжинэ.*
- 2.1.23 Аккруэл суурьт цогц УСНББОУС-ууд дахь УСНББОУС 20 нь холбоотой талууд болон тэдгээрийн холбогдох нэр томъёог тодорхойлж, хяналт

үүссэн тохиолдолд холбоотой талуудын харилцааны талаар тодруулга хийх, түүнчлэн холбоотой талуудын ажил гүйлгээний талаархи зарим мэдээллийн, үүн дотроо эрх бүхий албан тушаалтны нийт цалин урамшууллын талаархи мэдээллийн тодруулга хийхийг шаарддаг.

## **Хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал болон төсвийн зэрэгцүүлэлтийн тодруулга**

2.1.24 *Байгууллага нь дараах зүйлсийг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулахыг дэмжинэ:*

- (a) *Тухайн байгууллагын хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлагын талаархи мэдээлэл; ба*
- (б) *Хэрэв байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй бол төсвийн зэрэгцүүлэлт.*

2.1.25 Засгийн газрууд болон засгийн газрын байгууллагууд нь мөнгөнөөс гадна мэдэгдэхүйц хэмжээний нөөцийг хянадаг бөгөөд үйлчилгээ үзүүлэх өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ тэдгээр нөөцийг ашигладаг. Тэд өөрсдийн үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд зээл авч, мөн үйл ажиллагааныхаа явцад бусад өр болон өглөг үүсгэж, ирээдүйд капитал хөрөнгийн худалдан авалтын хувьд мөнгө зарцуулах амлалт өгч байдаг. Мөн тухайн тайлант үеийн туршид тэд өртөг зардал гаргаж, орлого бий болгох бөгөөд энэ нь ирээдүйн тайлант үед мөнгөн гүйлгээ үүсэхэд хүргэдэг. Мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу бэлтгэж болох бусад санхүүгийн тайланд тайлагнадаггүй. Гэвч засгийн газрууд нь өөрсдийн өр, бусад өр төлбөр, мөнгөн бус хөрөнгө, түүнчлэн тухайн тайлант үеийн турш дахь өөрсдийн үйл ажиллагааны өртөг зардал, холбогдох орлогын эх үүсвэр ба дүнгийн талаархи бүртгэлийг хөтөлж, хянан үнэлж, удирддаг. Хөрөнгө, өр төлбөр, түүнчлэн тодорхой хөтөлбөр болон үйл ажиллагааны өртөг, орлогын талаархи мэдээллийн тодруулга нь хариуцлагатай байдлыг сайжруулж, шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой мэдээллээр хангадаг тул энэ Стандартаар түүнийг сайшаан дэмжсэн.

2.1.26 Ийм тодруулга хийдэг байгууллагууд нь орлого, зардлыг түүний үйл ажиллагааны хувьд тохиромжтой байдлаар шинж төрлөөр эсвэл чиг үүргээр тодорхойлох, түүнчлэн хөрөнгө, өр төлбөрийг төрлөөр тодорхойлох, тухайлбал дараах байдлаар ангилахыг сайшаан дэмжинэ:

- (a) Хөрөнгийг авлага, хөрөнгө оруулалт эсвэл үндсэн хөрөнгө гэж ангилах; ба
- (б) Өр төлбөрийг төрлөөр нь өглөг, зээл, бусад өр төлбөр гэж, эсвэл эх үүсвэрээр ангилах.

Ийм тодруулга нь эхний удаад дэлгэрэнгүй биш байж болох боловч байгууллагууд нь аккрузл УСНББОУС-ын бүрэн мөрдөлтөнд шилжихийн хэрээр цаашид хөгжүүлэх ба өргөжүүлэхийг сайшаан дэмжинэ. Энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.5, 1.3.32-р параграфын шаардлагуудыг

хангахын тулд эдгээр тодруулга нь санхүүгийн мэдээллийн чанарын шинжүүдтэй нийцсэн байх ёстой бөгөөд түүнийг тодорхой дүрсэлж, шууд ойлгогдохоор байвал зохино.

- 2.1.27 Аккруэл суурьт УСНББОУС нь хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын талаархи нэмэлт мэдээллийг тодруулахад байгууллагуудад ач холбогдолтой заавар удирдамжаар хангадаг. Санал Болгосон Практик Удирдамж нь байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, түүний үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд ба хэрэгжилт, байгууллагын санхүүгийн тогтвортой байдал гэх мэт асуудлуудыг илүү сайн ойлгоход хэрэглэгчдэд туслах тодруулгын талаархи заавар удирдамжаар мөн хангадаг.

### **Төсвийн зэрэгцүүлэлт**

- 2.1.28 Улсын секторын байгууллагууд нь зөвшөөрөл олгох хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр болж болох төсвийн хуваарилалт буюу төсвийн бусад бүрэн эрх хэлбэрийн төсвийн хязгаарт ихэвчлэн захирагддаг. Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилтуудын нэг нь хууль ёсоор батлагдсан төсвийн дагуу мөнгийг олж авч, ашиглан зарцуулсан эсэх талаар тайлагнах явдал юм. Зарим улс оронд, энэ шаардлагыг хууль тогтоомжид тусгадаг. Өөрсдийн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллагууд нь энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.7.1-1.7.46-р параграфын шаардлагуудыг даган мөрдөх ёстой. Санхүүгийн тайлан болон төсвийг нягтлан бодох бүртгэлийн нэг ижил сууриар бэлтгэдэг тохиолдолд бусад байгууллагууд (өөрсдийн батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй байгууллагууд) нь тухайн тайлант үеийн төсөвлөсөн дүнтэй гүйцэтгэлийг зэрэгцүүлсэн тийм тодруулгыг санхүүгийн тайландаа тусгахыг энэ Стандартаар сайшаан дэмждэг. Эдгээр бусад байгууллагуудын хувьд төсөвтэй зэрэгцүүлсэн тайлагналыг янз бүрийн арга замаар толилуулж болно. Үүнд:

- (а) Төсөвлөсөн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хувьд тусдаа багана бүхий тэмдэглэл хэлбэрийн тодруулга. Төсөв буюу төсвийн хуваарилалтаас гажсан аливаа хэлбэлзлийг харуулсан баганыг иж бүрэн байдлын зорилгоор бас толилуулж болно; ба
- (б) Төсөвлөсөн дүнгээс хэтрээгүй гэсэн тодруулга. Хэрэв аливаа төсөвлөсөн дүн буюу төсвийн хуваарилалтыг хэтрүүлсэн, эсвэл төсвийн хуваарилалт болон бусад хэлбэрийн бүрэн эрхгүйгээр зарлага гаргасан бол тухайн санхүүгийн тайлан дахь холбогдох зүйлсэд хийсэн тэмдэглэл байдлаар дэлгэрэнгүй мэдээллийг тодруулж болно.

- 2.1.29 *Гүйцэтгэл болон төсөвлөсөн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг санхүүгийн тайландаа тодруулдаг байгууллагууд нь үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийн талаархи мэдээллийг агуулсан тайлан илтгэлд үүсгэсэн харилцан лавлагааг тэдгээр санхүүгийн тайланд тусган оруулахыг дэмжинэ.*



- 2.1.30 *Олон жилийн төсөв баталдаг байгууллагууд нь тухайн төсвийн хугацааны хувьд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох харилцан хамаарлын талаархи нэмэлт тэмдэглэл тодруулга хийхийг дэмжинэ.*
- 2.1.31 Төсвийн нэмэлт мэдээллийг, үүн дотроо үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийн талаархи мэдээллийг тухайн санхүүгийн тайлангаас бусад, баримт бичигт толилуулж болно. Гүйцэтгэл болон төсөвлөсөн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг санхүүгийн тайландаа тодруулдаг байгууллагууд нь ийм баримт бичгүүд дэх, ялангуяа төсөв ба гүйцэтгэлийг уг төсвийн санхүүгийн бус мэдээ, үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийн талаархи мэдээлэлтэй холбосон харилцан лавлагааг өөрсдийн санхүүгийн тайландаа тусган оруулахыг сайшаан дэмжинэ.
- 2.1.32 Энэ Стандартын 1.7.32-р параграфт тэмдэглэсэнчлэн, байгууллагууд нь олон жилийн төсвийн бүрэлдэхүүн дэх жил тутмын төсвийг тодорхойлохдоо янз бүрийн арга хандлага баримталдаг байж болно. Олон жилийн төсөв баталдаг байгууллагууд нь олон жилийн төсөв, түүнчлэн тухайн төсвийн хугацаан дахь жил тутмын бүрэлдэхүүн төсвүүд болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох харилцан хамаарал гэх мэт асуудлуудын талаар нэмэлт тодруулга хийхийг дэмжинэ.

## **Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

### **Тодорхойлолт**

- 2.1.33 *Дараах нэр томъёог Стандартын энэ хэсэгт доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:*

*Нэгтгэсэн санхүүгийн тайлан гэдэг нь хяналт тавигч байгууллага болон түүний хяналтанд буй байгууллагуудын мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдлийг нэг байгууллага байдлаар толилуулдаг тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайлан юм.*

*Байгууллагын хяналт: Байгууллага нь бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй бөгөөд уг бусад байгууллага дахь бүрэн эрхээрээ дамжуулан тэдгээр өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэх чадвар, боломжтой бол тухайн байгууллага нь тэрхүү бусад байгууллагыг хянана.*

*Хяналтанд буй байгууллага гэдэг нь өөр байгууллагын (хяналт тавигч байгууллага гэж нэрлэдэг) хяналтанд байдаг байгууллага юм.*

*Хяналт тавигч байгууллага гэдэг нь нэг буюу хэд хэдэн байгууллагыг хянадаг байгууллага юм.*

*Эдийн засгийн нэгдмэл байгууллага гэдэг нь хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй байгууллагууд юм.*

### **Эдийн засгийн нэгдмэл байгууллага**

- 2.1.34 Хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй аливаа байгууллагуудаас бүрдэх байгууллагуудын группыг санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлохын тулд энэ Стандартад “эдийн засгийн нэгдмэл байгууллага” гэсэн нэр томъёог ашигласан. Эдийн засгийн нэгдмэл байгууллагыг илэрхийлэхийн тулд зарим үед захиргааны байгууллага, санхүүгийн байгууллага, нэгтгэсэн байгууллага, групп гэх мэт бусад нэр томъёог ашигладаг. Нэг байгууллага нь нөгөө байгууллагыг санхүүгийн тайлагналын зорилгоор хянадаг эсэхийг үнэлэхдээ харгалзан үзэх хүчин зүйлсийг УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан-д* заасан.
- 2.1.35 Эдийн засгийн нэгдмэл байгууллага нь нийгмийн бодлогын болон арилжааны аль аль зорилго бүхий байгууллагуудыг агуулсан байж болно. Жишээлбэл; засгийн газрын орон сууцны хэлтэс нь нэрлэсэн төлбөртэй орон сууцаар хангадаг байгууллагууд болон арилжааны сууриар орон сууцаар хангадаг байгууллагуудыг агуулсан эдийн засгийн нэгдмэл байгууллага байж болох юм.
- 2.1.36 Улс орны Үндсэн хуулийн зохицуулалтыг, ялангуяа засгийн газрын бүрэн эрхийг хязгаарлах болон хуваарилах арга зам, төрийн тогтолцоог хэрхэн бүрдүүлж, ажилуулж байгаа эсэхийг харгалзан үзсэнээр эдийн засгийн нэгдмэл байгууллагыг тодорхойлох шаардлагатай байдаг. Жишээлбэл; гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал, шүүх засаглалтай улс орны хувьд эдгээр нь нэгдсэн санхүүгийн тайланг шаардах хэрэглэгч бүхий эдийн засгийн нэгдмэл байгууллагыг хамтдаа бүрдүүлж болох юм. Ийм нэгтгэсэн санхүүгийн тайланг ихэвчлэн нийт засгийн газрын санхүүгийн тайлан гэж нэрлэдэг.

### **Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн цар хүрээ**

- 2.1.37 *2.1.40-р параграфт заасан хяналт тавигч байгууллагаас бусад, хяналт тавигч байгууллага нь нэгтгэлийн дараах горимуудыг хэрэглэснээр өөрийн хяналтанд буй гадаад болон дотоодын бүх байгууллагуудыг нэгтгэж, нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулахыг сайшаан дэмжинэ:*
- (а) *Мөнгөний үлдэгдлүүд ба эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох мөнгөн ажил гүйлгээг бүхэлд нь устгаж цэвэрлэнэ;*
  - (б) *Нэгтгэлд ашигласан санхүүгийн тайлангуудыг өөр өөр тайлангийн өдрөөр бэлтгэсэн тохиолдолд тэдгээр өдрүүд ба уг хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайлангийн өдрийн хооронд гарч тохиолдсон мэдэгдэхүйн дүнтэй мөнгөн ажил гүйлгээнүүдийн үр нөлөөний хувьд залруулга хийнэ; ба*
  - (в) *Адил төсөөтэй мөнгөн ажил гүйлгээний хувьд нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлого баримталснаар нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэнэ. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ*

*нягтлан бодох бүртгэлийн нэгдмэл бодлого баримтлах практик боломжгүй бол нягтлан бодох бүртгэлийн өөр бодлого хэрэглэсэн зүйлсийн тухайн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь хувийн жингийн хамтаар ийм практик боломжгүй байдлын талаархи тодруулгыг хийнэ.*

- 2.1.38 *2.1.40-р параграфт заасан хяналт тавигч байгууллагаас бусад, хяналт тавигч байгууллага нь өөрийн хяналтанд буй бүх байгууллагуудаа нэгтгэсэн, тийм нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулдаггүй тохиолдолд тус байгууллага нь төсвийн сектор, засгийн газрын үндсэн секторыг төлөөлөн илэрхийлэх өөрийн хяналтанд буй байгууллагуудын, эсвэл засгийн газрын гол үйл ажиллагааг илэрхийлэх ба хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангах бусад эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулахыг сайшаан дэмжинэ.*
- 2.1.39 *2.1.37-р параграфт заасанчлан, хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй байгууллагуудаас бүрдэх санхүүгийн тайлан гэдгийг илэрхийлэхийн тулд эдийн засгийн нэгдмэл байгууллага нь “нэгтгэсэн санхүүгийн тайлан” гэсэн нэр томъёог ашигладаг. 2.1.37-р параграфт заасанчлан, хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй бүх байгууллагуудаас бүрдээгүй эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайланг шууд ойлгогдохоор бөгөөд тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагыг бүрдүүлж буй байгууллагуудын ангилал болон шинж чанарыг тодорхой дүрслэн тайлбарлах тийм нэр томъёогоор илэрхийлэх хэрэгтэй.*
- 2.1.40 *Дараах бүх нөхцлийг хангаж буй хяналт тавигч байгууллагын хувьд нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагагүй юм:*
- (a) *Энэ нь өөрөө өөр байгууллагын хяналтанд буй байгууллага бөгөөд түүний хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг тухайн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангаар хангадаг, харин бүрэн бус эзэмшлийн хяналтанд буй байгууллага байх тохиолдолд түүний бусад бүх эздэд, үүн дотроо саналын эрхгүй эзэмшигчдэд уг байгууллага нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулахгүй гэдгийг мэдэгдсэн бөгөөд тэд эсэргүүцээгүй;*
  - (б) *Түүний өрийн буюу өмчийн хэрэглүүрийг хөрөнгийн зах зээл (дотоодын буюу гадаадын хөрөнгийн бирж эсвэл орон нутгийн болон бүс нутгийн албан бус зах зээл)-д арилжаалдаггүй;*
  - (в) *Байгууллага нь хөрөнгийн зах зээлд ямар нэг санхүүгийн хэрэглүүр гаргах зорилгоор өөрийн санхүүгийн тайланг үнэт цаасны хороо буюу бусад зохицуулагч байгууллагад танилцуулаагүй, мөн ингэж танилцуулахаар бэлтгээгүй; ба*
  - (г) *Түүний хамгийн эцсийн эсвэл завсрын аль нэг хяналт тавигч байгууллага нь олон нийт ашиглах боломжтой ба Мөнгөн суурьт УСНББОУС эсвэл аккруэл УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэдэг.*

- 2.1.41 Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд, засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь бүхэлдээ тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хянаж буй мөнгөн нөөцийг ихэвчлэн сонирхдог бөгөөд энэ талаар мэдээлэхийг шаарддаг. Тусдаа хуулийн этгээдүүдийн хууль эрх зүйн хил хязгаарыг үл харгалзан тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын талаархи санхүүгийн мэдээллийг нэг байгууллага байдлаар толилуулдаг, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь энэхүү хэрэгцээ шаардлагыг хангадаг.
- 2.1.42 Хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэн харуулсан санхүүгийн тайлангийн хэрэглэгчид оршин байх магадлалтай тохиолдолд засгийн газрууд болон улсын секторын хяналт тавигч бусад байгууллагууд нь ийм санхүүгийн тайлан толилуулахыг энэхүү Стандартаар сайшаан дэмждэг.
- 2.1.43 Засгийн газар болон түүний хяналтанд буй бүх байгууллагуудаас бүрдсэн эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь тухайн тайлангийн өдрөөр уг засгийн газар шууд буюу өөрийн хяналтанд буй байгууллагуудаар дамжуулан шууд бусаар хянаж буй мөнгөн нөөц, түүнчлэн тэрхүү тайлант үеийн туршид мөнгөн нөөцөд гарсан өөрчлөлтийн талаархи мэдээллээр хангадаг. Жишээлбэл; эрүүл мэндийн яам эсвэл боловсролын газар гэх мэт улсын секторын бусад эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь уг яам буюу газрын хянаж буй мөнгөн нөөц, түүнчлэн тайлант үеийн туршид тэдгээр нөөцөд гарсан өөрчлөлтийн талаархи мэдээллээр хангадаг.
- 2.1.44 Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэлт нь өртөг зардалгүй үйл явц биш юм. Иймээс тухайн тайланг бэлтгэсний үр өгөөж нь бэлтгэх өртөг зардлыг зөвтгөн баталдаг байх чухал ач холбогдолтой. Өөрөө өөр байгууллагын хяналтанд байдаг, тийм хяналт тавигч байгууллага нь 2.1.40-р параграфт дурдсан нөхцөл байдалд нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх ихэвчлэн шаардлагагүй байдаг. Яагаад гэвэл, түүний хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланг Мөнгөн суурьт УСНББОУС эсвэл аккруэл УСНББОУС-ын шаардлагад нийцүүлэн бэлтгэдэг бөгөөд 2.1.40-р параграфт тодорхойлсон бусад нөхцлүүдийг мөрддөг тохиолдолд мөнгөн суурьт санхүүгийн тайланд толилуулсан мэдээллийн хувьд хэрэглэгчдийн хэрэгцээг ихэвчлэн уг нэгтгэсэн санхүүгийн тайлангаар хангадаг. Гэвч өөр зарим тохиолдолд нийт засгийн газрын түвшний нэгтгэсэн санхүүгийн тайлан нь засгийн газрын гол секторууд буюу үйл ажиллагаануудын хувьд хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахгүй байж болох юм. Олон улс орны хувьд, ийм хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг харгалзан үзэх зорилго бүхий хуульчлан тогтоосон санхүүгийн тайлагналын шаардлагууд байдаг.
- 2.1.45 Зарим тохиолдолд өөр байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхтэй байгууллага нь тэрхүү бусад байгууллагын үйл ажиллагаанаас өгөөж хүртэх боломжгүй байж болох юм. Жишээлбэл; тухайн байгууллага нь уг бусад байгууллагын үйл ажиллагаанаас өгөөж хүртэхийн тулд түүний үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах гаднын урт хугацааны хатуу хязгаарлалтанд

тэрхүү бусад байгууллага захирагддаг байх. Ийм байгууллагын мөнгөн гүйлгээ болон мөнгөний үлдэгдлийг тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахгүй. Яагаад гэвэл, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бараа, үйлчилгээ нийлүүлэхдээ ашиглаж болох ба өөр бусад байдлаар тухайн тайлагнагч байгууллагад үр өгөөж бий болгох уг засгийн газрын буюу улсын секторын бусад тайлагнагч байгууллагын мөнгөн нөөцийн талаархи мэдээллийг толилуулдаг.

- 2.1.46 Мөнгөн суурьт УСНББОУС-ыг мөрддөг байгууллагын хамгийн эцсийн эсвэл завсрын аль нэг хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг аккруэл сууриар бэлтгэн толилуулж болно гэж 2.1.40(г) параграфт заасан. Зарим улс оронд ийм байж болох боловч хамгийн эцсийн эсвэл завсрын хяналт тавигч байгууллага нь мөнгөн суурийг мөрддөг хяналтанд буй байгууллагуудын хувьд аккруэл УСНББОУС-ыг даган мөрдөхөд шаардлагатай мэдээллийг эмхлэн бүрдүүлэхдээ практикын мэдэгдэхүйц асуудлуудтай тулгарах магадлалтай байдаг.

### **Нэгтгэсэн санхүүгийн тайланд шилжилт**

- 2.1.47 Засгийн газар болон улсын секторын бусад байгууллагууд нь маш олон байгууллагуудыг, үүн дотроо засгийн газрын хэлтэс газрууд, агентлагууд, улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудыг хянадаг байж болно. Хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэдэг тийм нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бэлтгэлт нь нарийн цогц бөгөөд нэлээд нөөц шаардсан үйл явц байдаг. Зарим засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагууд нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахдаа мэдэгдэхүйц саад бэрхшээлтэй тулгардаг бөгөөд бүрэн аккруэл суурьт шилжилтийг эхлүүлснээр тэд бүрэн нэгтгэсэн санхүүгийн тайланг богино буюу дунд хугацаанд бэлтгэх боломжгүй байж болох юм. Энэ нь хяналтанд буй бүх байгууллагуудаас мэдээг цаг хугацаанд нь цуглуулж, боловсруулах уг засгийн газрын болон бусад байгууллагын чадвар боломжийг хязгаарлах хүчин чадлын хязгаарлагдмал байдлаас шалтгаалж, санхүүгийн тайланг хяналтанд буй бүх байгууллагууд биш, харин хяналтанд буй байгууллагуудын дэд бүлгүүдийн хувьд бэлтгэх хууль тогтоомжийн болон бусад шаардлагуудаас, эсвэл бусад учир шалтгаанаас хамаардаг байж болно.
- 2.1.48 Мөнгөн сууриар тайлагнадаг засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагууд нь санхүүгийн тайлагналын аккруэл суурьт шилждэг бөгөөд нэгтгэлд тулгарч буй саад бэрхшээлийг даван туулахын тулд чадавхи, систем, хууль тогтоомжийн хүрээг боловсруулан хөгжүүлдэг тул хяналтанд буй нэмэлт байгууллагуудын талаархи мэдээллийг мөнгөн суурьт санхүүгийн тайланд тусгах боломж нэмэгдэх юм. Засгийн газруудын хувьд, тухайлбал, төсвийн сектор ба засгийн газрын үндсэн секторыг илэрхийлэх хяналтанд буй байгууллагуудаас, эсвэл засгийн газрын чухал үйл ажиллагаануудын бусад төлөөллөөс бүрдэх эдийн засгийн нэгдмэл байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлага, мөнгөний үлдэгдлийн талаархи мэдээллийг тайлагнадаг тийм санхүүгийн тайлан бэлтгэлт нь

хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдэд ач холбогдолтой тухайн засгийн газрын гол секторуудын талаархи мэдээллээр хангана. Бүрэн нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулдаггүй хяналт тавигч байгууллага нь санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын дагуу бүрэн нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулах шилжилтийн хувьд завсрын алхам болгон тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагад зориулсан санхүүгийн тайланг толилуулахыг энэхүү Стандартаар сайшаан дэмждэг. Хяналтанд буй бүх байгууллагуудаа нэгтгэдэггүй, засгийн газрын агентлагууд нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдэд ач холбогдолтой бөгөөд өөрсдийн үйл ажиллагааны дэд бүлгийг төлөөлөн илэрхийлэх хяналтанд буй байгууллагуудыг нэгтгэсэн, тийм санхүүгийн тайланг толилуулахыг бас сайшаан дэмждэг.

- 2.1.49 Энэ Стандартын 2.1.37-р параграфт заасанчлан, хяналтанд буй бүх байгууллагуудын “бүрэн нэгтгэл”-ийг толилуулах тийм санхүүгийн тайланг гэдгийг илэрхийлэхийн тулд “нэгтгэсэн санхүүгийн тайлан” гэсэн нэр томъёог ашигладаг. Хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй бүх байгууллагуудыг тусган оруулаагүй тийм эдийн засгийн нэгдмэл байгууллагын талаархи мэдээллийг толилуулдаг санхүүгийн тайланг дүрслэн тайлбарлахын тулд “нэгтгэсэн санхүүгийн тайлан” гэдгээс өөр нэр томъёог ашиглана. Уг нэр томъёо нь шууд ойлгогдохоор бөгөөд тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагыг бүрдүүлж буй байгууллагуудын ангилал болон шинж чанарыг тодорхой дүрслэн тайлбарладаг байвал зохино. Тохиромжтой нэр томъёоны сонголт нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал юм. Санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийн, үүн дотроо ойлгомжтой байх ба тухайн толилуулсан эдийн засгийн нэгдмэл байгууллагын үнэн зөв илэрхийллийн хүрээнд шүүн тунгаалт хийх хэрэгтэй. Ийм санхүүгийн тайланг бэлтгэдэг үндэсний, мужийн/бүсийн болон орон нутгийн засгийн газрын хувьд тухайлбал, төсвийн секторын эсвэл засгийн газрын үндсэн секторын санхүүгийн тайланг гэх мэт нэр томъёо тохиромжтой байж болох юм.

## **Нэгтгэлийн горим**

- 2.1.50 Энэ Стандартаар сайшаан дэмжсэнчлэн, 2.1.37-р параграфт дурдсан, нэгтгэлийн горим нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх бүх байгууллагуудын нэгтгэсэн санхүүгийн тайланг эдийн засгийн нэг нэгж байдлаар бэлтгэх суурь үндэслэлээр хангадаг.
- 2.1.51 Энэ Стандартаар сайшаан дэмжсэн, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллага ба түүний хувьд гаднын байх бусад байгууллагуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээг тусгадаг. Иймээс тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээг давхар тооцохоос сэргийлэхийн тулд устгаж цэвэрлэдэг. Жишээлбэл; засгийн газрын нэг хэлтэс нь засгийн газрын өөр нэг хэлтэст биет хөрөнгийг борлуулж болох юм. Нийт засгийн газрын тайлагнагч байгууллагын хувьд цэвэр мөнгөн үр нөлөө нь тэг учраас уг нийт засгийн газрын тайлагнагч байгууллагын мөнгөн орлого, мөнгөн зарлагыг

илүү илэрхийлэхээс зайлсхийхийн тулд энэхүү ажил гүйлгээг устгаж, цэвэрлэх шаардлагатай. Засгийн газрын байгууллага нь улсын секторын санхүүгийн байгууллагад мөнгө сангаа байршуулдаг байж болно. Ийм үлдэгдэл нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх үлдэгдлийг илэрхийлэх учраас нийт засгийн газрын түвшинд үүнийг устгаж цэвэрлэнэ. Үүнтэй адилаар, гадаадад үйл ажиллагаа явуулдаг, улсын секторын худалдаа арилжааны байгууллага нь засгийн газрын хэлтэст төлбөр төлсөн бөгөөд энэ нь тухайн тайлангийн өдрөөр замд яваа мөнгө байж болох юм. Энэ тохиолдолд нийт засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ уг ажил гүйлгээг устгаж цэвэрлэхгүй байх нь тухайн засгийн газрын түвшний эдийн засгийн нэгдмэл байгууллагын мөнгөний үлдэгдлийг дутуу, харин мөнгө зарлагыг илүү илэрхийлэхэд хүргэнэ. Харин улсын секторын худалдаа арилжааны байгууллагыг тусган оруулаагүй тухайлбал, засгийн газрын үндсэн секторыг илэрхийлэх тийм бүлэг байгууллагын хувьд бэлтгэсэн санхүүгийн тайланд уг ажил гүйлгээг устгаж цэвэрлэхгүй.

2.1.52 Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх бие даасан байгууллагууд нь мөнгөн орлого, мөнгөн зарлагын ангилал болон өөрсдийн санхүүгийн тайлангийн толилуулгын хувьд өөр өөр бодлогуудыг мөрддөг байж болно. Ийм ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн орлого буюу мөнгөн зарлагыг хэрэв практик боломжтой бол нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгдмэл арга маягаар ангилж, толилуулна.

### **Нэгтгэлийн тодруулга**

2.1.53 *2.1.37-р параграф дахь сайшаан дэмжилтэнд нийцүүлэн бэлтгэсэн тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлдээ байгууллага нь дараах зүйлсийг тодруулахыг сайшаан дэмжинэ:*

- (а) *Хяналтанд буй томоохон байгууллагуудын жагсаалт, үүн дотроо тухайн хяналтанд буй байгууллагын нэр ба үйл ажиллагаа явуулдаг улс орон (хяналт тавигч байгууллагын улс орноос өөр тохиолдолд); ба*
- (б) *Хяналтанд буй байгууллагыг нэгтгээгүй шалтгаан.*
- (в) *Хяналтанд буй байгууллагууд дахь өмчлөлийн хувь оролцооны хэмжээ ба тэрхүү өмчлөлийн хувь оролцоог хэрхэн тодорхойлсон талаархи тайлбар тодорхойлолт; ба*
- (г) *Хэрэв хамааралтай бол хяналт тавигч байгууллага нь дараах шинж чанартай эсэхийг тодорхойлохдоо харгалзан үзсэн хүчин зүйлс:*
  - (i) *Хэдийгээр бусад байгууллагын (буюу байгууллагуудын) саналын эрхийн тэн хагасаас бага хэсгийг эзэмшдэг боловч тэрхүү бусад байгууллагыг (буюу байгууллагуудын ангиллыг) хянадаг эсэх, түүнчлэн хяналт хэрхэн оршин буй талаархи тайлбарын хамт;*

- (ii) *Хэдийгээр бусад байгууллагын (буюу байгууллагуудын) саналын эрхийн тэн хагасаас илүү хэсгийг эзэмшдэг боловч тэрхүү бусад байгууллагыг (буюу байгууллагуудын ангиллыг) хянадаггүй эсэх.*

2.1.54 2.1.37-р параграфт сайшаан дэмжсэнчлэн, хяналтанд буй бүх биш боловч зарим байгууллагуудыг нэгтгэдэг тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд санхүүгийн тайланг толилуулж буй байгууллага нь 2.1.53-р параграфт сайшаан дэмжсэн тодруулгыг дараах зүйлсийн хамтаар тэрхүү санхүүгийн тайлангийн тэмдэглэлдээ тодруулахыг сайшаан дэмжинэ.

(a) *Группын санхүүгийн тайланд тусгасан болон түүнд оруулаагүй хассан хяналтанд буй байгууллагын ангиудын (буюу шинж чанарын) тайлбар тодорхойлолт, түүнчлэн аливаа ангиудыг уг группын данс тооцооноос хассан шалтгааны талаархи тайлбарын хамт; ба*

(б) *Өмнөх тайлант үеийн санхүүгийн тайлангийн толилуулгаас хойш уг группын санхүүгийн тайланд нэмж оруулсан эсвэл түүнээс хассан томоохон байгууллагуудын жагсаалт.*

2.1.55 2.1.37-р параграфт сайшаан дэмжсэнчлэн, нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулдаггүй хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагуудыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа тайлагнахад ашигласан аргыг тэрхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулаагүй шалтгааны хамт тодруулахыг сайшаан дэмждэг. Нэгтгэсэн санхүүгийн тайланг хэвлэн нийтэлдэг өөрийн хяналт тавигч байгууллагын нэр болон үндсэн хаягийг уг байгууллага тодруулахыг мөн сайшаан дэмжинэ.

2.1.56 2.1.53 ба 2.1.54-р параграфт сайшаан дэмжсэн тодруулга нь 2.1.37-р параграф дахь сайшаан дэмжилтэнд нийцүүлэн бэлтгэсэн, бүрэн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн, түүнчлэн 2.1.38-р параграф дахь сайшаан дэмжилтийн дагуу түүний хяналтанд буй байгууллагуудын дэд хэсгүүдийг нэгтгэдэг санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн болон гол шинжүүдийн талаархи мэдээллээр хэрэглэгчдийг хангадаг. 2.1.55-р параграфт сайшаан дэмжсэн тодруулга нь нэгтгэсэн санхүүгийн тайлангаа уг хяналт тавигч байгууллага бэлтгэдэг эсэх, хэрэв бэлтгэдэггүй бол хяналтанд буй байгууллагуудаа тайлагнахын тулд ашигласан аргыг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог.

**Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны бусад нэгжүүдийн олж эзэмшилт ба данснаас хасалт**

2.1.57 *Байгууллага нь хяналтанд буй байгууллагууд эсвэл үйл ажиллагааны бусад нэгжүүдийн худалдан авалт ба данснаас хасалтаас үүссэн нийт мөнгөн гүйлгээг тусад нь тодруулж, толилуулахыг сайшаан дэмжинэ.*

2.1.58 *Байгууллага нь хяналтанд буй байгууллагууд эсвэл үйл ажиллагааны бусад нэгжүүдийн тухайн тайлант үеийн турш дахь олж эзэмшилт ба*



*данснаас хасалтын аль алины хувьд дараах зүйл тус бүрийг нийт дүнгээр санхүүгийн тайлангийн тэмдэглэлдээ тодруулахыг дэмжинэ:*

- (а) *Олж эзэмшилт эсвэл данснаас хасалтын нийт дүн (үүн дотроо, мөнгөн болон бусад хөрөнгө);*
- (б) *Олж эзэмшилт эсвэл данснаас хасалтын төлбөрөөс мөнгөөр барагдуулсан хэсэг; ба*
- (в) *Олж эзэмшсэн эсвэл данснаас хассан уг хяналтанд буй байгууллага буюу үйл ажиллагааны нэгж дэх мөнгөний дүн.*

2.1.59 Хяналтанд буй байгууллагууд ба бусад үйл ажиллагаануудын олж эзэмшилт болон данснаас хасалтын мөнгөн гүйлгээний үр нөлөөг уг олж эзэмшсэн эсвэл данснаас хассан хөрөнгө, өр төлбөрийн дүнгийн тусдаа тодруулгын хамтаар тусад нь толилуулах нь тэдгээр мөнгөн гүйлгээг тухайн байгууллагын бусад үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн орлого, зарлагаас ялган зааглахад тусалдаг. Олж эзэмшилт ба данснаас хасалтын аль алины үр нөлөөг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгохын тулд данснаас хасалтын мөнгөн гүйлгээний үр нөлөөг олж эзэмшилтийн мөнгөн гүйлгээнээс хасахгүй.

2.1.60 Худалдан авалт эсвэл борлуулалтын төлбөр байдлаар төлсөн эсвэл хүлээн авсан мөнгөний нийт дүнг уг олж эзэмшсэн эсвэл данснаас хассан мөнгийг хассан цэвэр дүнгээр мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнана.

2.1.61 Байгууллагын хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодруулга хийхийг 2.1.24-р параграфт сайшаан дэмжсэн. Олж эзэмшсэн эсвэл данснаас хассан уг хяналтанд буй байгууллага буюу үйл ажиллагааны нэгжийн мөнгөн хөрөнгө, мөнгөн гүйлгээнээс бусад, хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг мөн гол ангилал тус бүрээр нэгтгэн товчоолсноор тусад нь толилуулж болно. Ийм тодруулга хийх тохиолдолд энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.32-р параграфын шаардлагын дагуу тухайн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг ойлгомжтой тодорхойлох ба тэдгээрийг хүлээн зөвшөөрсөн болон хэмжсэн суурийг тайлбарлана.

### **Хамтын хэлэлцээр**

2.1.62 *Байгууллага нь тухайн тайлант үеийн турш дахь түүний мөнгөн орлого, зарлага болон уг тайлангийн өдрөөрх мөнгөний үлдэгдлийг үнэн зөв толилуулахад зайлшгүй шаардлагатай хамтын хэлэлцээрүүдийн талаар тодруулга хийхийг сайшаан дэмжинэ.*

2.1.63 Хамтын хэлэлцээр гэдэг нь хамтын хяналт бүхий хоёр буюу хэд хэдэн талуудын хоорондох хэлэлцээр юм. Улсын секторын олон байгууллагууд нь төрөл бүрийн үйл ажиллагаа явуулахын тулд хамтын хэлэлцээр хийдэг. Эдгээр үйл ажиллагааны шинж төрөл нь арилжааны үйл ажиллагаанаас эхлээд үнэ төлбөргүй нийгмийн үйлчилгээ хүртэл өргөн хүрээтэй байдаг. Хамтын хэлэлцээрийн нөхцлүүдийг гэрээ буюу бусад заавал биелүүлэх хэлцлээр тогтоодог бөгөөд хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч бүрийн

анхны хувь оролцоо, тэдгээр хувь оруулагч нэг бүрд хамаарах орлого буюу бусад өгөөж (хэрэв байгаа бол) болон зардлын хувь хэмжээг тусгайлан заадаг. Мөнгөн сууриар тайлагнадаг байгууллагууд нь ерөнхийдөө дараах байдлаар тайлагнана:

- (а) Хамтын хэлэлцээр дэх хувь оролцооны худалдан авалт ба тухайн хамтын хэлэлцээрийн тасралтгүй үйл ажиллагаанд зарцуулсан мөнгийг мөнгөн зарлага байдлаар; ба
- (б) Хамтын хэлэлцээрээс хүлээн авсан мөнгийг мөнгөн орлого байдлаар.

Хамтын хэлэлцээрийн талаархи тодруулга нь томоохон хамтын хэлэлцээр дэх хувь оролцооны жагсаалт болон тайлбар тодорхойлолтыг агуулсан байж болно. Аккруэл суурьт цогц УСНББОУС-ууд дахь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт УСНББОУС 36, “Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт” ба УСНББОУС 37, “Хамтын Хэлэлцээр” нь хамтын хэлэлцээрийг байгуулж болох янз бүрийн хэлбэр ба бүтэц, түүнчлэн хийж болох боломжит нэмэлт тодруулгын талаархи заавар удирдамжаар хангадаг. Байгууллага нь “хараат байгууллага” эсэх, хэлэлцээр нь УСНББОУС 36, УСНББОУС 37-д тодорхойлсон “хамтын хэлэлцээр” эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 35-д заасан, “хяналт”-ын тодорхойлолт болон тайлбарыг харгалзан үзэх шаардлагатай юм.

### **Хэт инфляцитай эдийн засгийн үеийн санхүүгийн тайлагнал**

2.1.64 Хэт инфляцитай эдийн засгийн үед санхүүгийн тайланг дахин илэрхийлэхгүйгээр тухайн орон нутгийн валютаар толилуулах нь ач холбогдолгүй юм. Өөр өөр цаг хугацаанд, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн нэг тайлант үеийн дотор гарч тохиолдсон ажил гүйлгээ ба бусад үйл явдлуудаас үүссэн дүнгүүдийн зэрэгцүүлэлт нь төөрөгдөлд хүргэхүйц тийм хувь хэмжээгээр мөнгөний худалдан авах чадвар буурч байдаг.

2.1.65 Энэ Стандарт нь хэт инфляци үүссэн гэж үзэхэд хүргэх үнэмлэхүй дүнг тогтоодоггүй. Энэ Стандартад сайшаан дэмжсэний дагуу санхүүгийн тайланг хэзээ дахин илэрхийлэх шаардлагатай эсэхийг тогтоох нь шүүн тунгаалтын асуудал юм. Хэт инфляци үүссэн гэдгийг илэрхийлэх улс орны эдийн засгийн шинж байдлуудад дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- (а) Ард түмэн нь өөрийн эд баялгийг мөнгөн бус хөрөнгөөр эсвэл харьцангуй тогтвортой гадаад валютаар хадгалахыг эрхэмлэдэг байх. Худалдан авах чадварыг хадгалахын тулд эзэмшиж буй дотоодын валютаар нэн даруй хөрөнгө оруулалт хийдэг байх;
- (б) Ард түмэн нь мөнгөн дүнг дотоодын валютаар бус харин харьцангуй тогтвортой гадаад валютаар харгалзан үздэг байх. Үнийг мөн ийм гадаад валютаар тогтоож болох юм;
- (в) Хэдийгээр зээлийн хугацаа богино байлаа ч гэсэн зээлээр борлуулалт ба худалдан авалт нь тухайн зээлийн хугацааны туршид

худалдан авах чадварт гарахаар хүлээгдэж буй алдагдлыг нөхөх үнээр тооцогдох;

- (г) Хүүний түвшин, цалин хөлс ба үнэ нь үнийн индекстэй холбогдсон байх;
- (д) Сүүлийн гурван жилийн инфляцийн хуримтлагдсан түвшин нь 100 хувьд ойртох буюу түүнээс давж гарах.

### **Санхүүгийн тайлангийн дахин илэрхийлэлт**

2.1.66 *Хэт инфляцитай эдийн засгийн валютаар тайлагнаж буй байгууллага нь дараах зүйлсийг гүйцэтгэхийг сайшаан дэмжинэ:*

- (а) *Тухайн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр өөрийн мөнгөн орлого, зарлагын тайлан болон бусад санхүүгийн тайланг дахин илэрхийлэх;*
- (б) *Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл болон түүнээс өмнөх тайлант үеүдийн аливаа мэдээллийг тухайн тайлангийн өдрөөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр дахин илэрхийлэх; ба*
- (в) *Худалдан авалтын ерөнхий чадварын өөрчлөлтийг тусгасан үнийн ерөнхий индекс ашиглах. Тухайн нэг эдийн засгийн үеийн валютаар тайлагнаж буй бүх байгууллагууд нь мөн нэг ижил индекс ашиглах хэрэгтэй.*

2.1.67 *Байгууллага нь дараах тодруулга хийхийг дэмжинэ:*

- (а) *Мөнгөн орлого, зарлагын тайлан, бусад санхүүгийн тайлан болон өмнөх тайлант үеүдийн харгалзах үзүүлэлтийг уг толилуулгын валютын худалдан авалтын ерөнхий чадварын өөрчлөлтийн хувьд дахин илэрхийлсэн бөгөөд ингэснээр эдгээр нь тухайн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлэгдсэн талаархи тодруулга; ба*
- (б) *Тухайн тайлангийн өдрөөрх үнийн индексийн тодорхойлолт ба түвшин, түүнчлэн уг тайлант үед болон өмнөх тайлант үеийн туршид энэхүү индексэд орсон өөрчлөлт.*

2.1.68 Үнэ нь улс төр, эдийн засаг, нийгмийн янз бүрийн олон хүчин зүйлсийн үр дүнд цаг хугацааны явцад өөрчлөгдөж байдаг. Эрэлт, нийлүүлэлтийн өөрчлөлт, технологийн өөрчлөлт гэх мэт тусгай хүчин зүйлс нь үнэ нэг нэгнээсээ үл хамааран мэдэгдэхүйц хэмжээгээр өсөх эсвэл буурахад хүргэж болох юм. Түүнчлэн ерөнхий хүчин зүйлс нь үнийн ерөнхий түвшний өөрчлөлтөнд, ингэснээр мөнгөний ерөнхий худалдан авах чадварын өөрчлөлтөнд хүргэж болно.

2.1.69 Хэт инфляцитай эдийн засгийн үед санхүүгийн тайланг тухайн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлснээр уг санхүүгийн тайлангийн ач холбогдол эрс нэмэгддэг. Иймээс дээрх 2.1.66 ба 2.1.67-р параграфт заасан, арга хандлага ба тодруулгыг сайшаан дэмждэг. Дахин илэрхийлээгүй санхүүгийн тайлангийн нэмэлт гүйцээлт биш, харин анхдагч

толилуулга байдлаар энэхүү мэдээллийг толилуулахыг сайшаан дэмжинэ. Дахин илэрхийлэлтээс өмнөх мөнгөн орлого, зарлагын тайлан болон бусад санхүүгийн тайлангийн тусдаа толилуулгыг дэмждэггүй.

- 2.1.70 Мөнгөн орлого, зарлагын тайлан дахь бүх зүйлсийг тухайн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлнэ. Иймээс мөнгөн орлого, зарлагын тайланд эсвэл бусад санхүүгийн тайланд тусгасан бүх дүнгүүдийг, үүн дотроо гуравдагч талын аливаа төлбөрийг тэдгээр орлого, зарлагыг анх бүртгэсэн өдрөөс хойшхи үнийн ерөнхий индексийн өөрчлөлтийг ашигласнаар дахин илэрхийлнэ.
- 2.1.71 Улсын секторын олон байгууллагууд нь төсөвтэй зэрэгцүүлэх боломж бүрдүүлэхийн тулд холбогдох төсвийн мэдээллийг өөрсдийн санхүүгийн тайланд тусган оруулдаг. Ийм тохиолдолд төсвийн мэдээллийг мөн энэхүү Стандартын дагуу дахин илэрхийлэхийг сайшаан дэмжинэ.

### **Зэрэгцүүлэгдэх мэдээлэл**

- 2.1.72 Өмнөх тайлант үеүдтэй хийх зэрэгцүүлэлт нь ач холбогдолтой бол тэрхүү зэрэгцүүлэгдэх санхүүгийн тайлангуудыг тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр толилуулахын тулд өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг үнийн ерөнхий индекс ашиглан дахин илэрхийлдэг. Өмнөх үеүдэд хамаарах тодруулсан мэдээллийг мөн тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлнэ.

### **Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

- 2.1.73 Хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлагнадаг, хяналт тавигч байгууллага нь мөн хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютуудаар тайлагнадаг, хяналтанд буй байгууллагуудтай байж болох юм. Мөнгөн орлого, зарлагын тайлан ба бусад санхүүгийн тайланг тууштай сууриар бэлтгэх ёстой бол хяналт тавигч байгууллагын бэлтгэдэг нэгтгэсэн санхүүгийн тайланд тэдгээр хяналтанд буй байгууллагуудыг тусган оруулахын өмнө, тухайн хяналтанд буй байгууллагын тайлагнадаг валютад хамаарах улс орны үнийн ерөнхий индексийг ашигласнаар тийм аливаа хяналтанд буй байгууллагуудын санхүүгийн тайланг дахин илэрхийлнэ. Ийм хяналтанд буй байгууллага нь гадаад дахь хяналтанд буй байгууллага байх тохиолдолд түүний дахин илэрхийлсэн санхүүгийн тайланг хаалтын ханшаар хөрвүүлнэ.
- 2.1.74 Хэрэв тайлант үеийн эцэс нь өөр байх санхүүгийн тайлангуудыг нэгтгэвэл, мөнгөн зүйлс эсвэл мөнгөн бус зүйлс гэдгээс үл хамааран бүх зүйлсийг тухайн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр дахин илэрхийлэх шаардлагатай.

### **Үнийн ерөнхий индексийн сонголт ба хэрэглээ**

- 2.1.75 Энэ Стандартаар сайшаан дэмжсэн арга хандлагын дагуу санхүүгийн тайлангийн дахин илэрхийлэлт нь худалдан авалтын ерөнхий чадварын өөрчлөлтийг тусгасан үнийн ерөнхий индекс ашиглахыг шаарддаг. Тухайн

нэг эдийн засгийн үеийн валютаар тайлагнаж буй бүх байгууллагууд нь мөн нэг ижил индекс ашиглах хэрэгтэй гэж үздэг.

- 2.1.76 Энэ Стандартаар сайшаан дэмжсэн тодруулгууд нь хэт инфляцийн үр нөлөөг тухайн санхүүгийн тайланд тусгах суурийг тодорхой болгох зорилготой байдаг. Эдгээр нь мөн уг суурь болон холбогдох дүнгүүдийг ойлгоход ач холбогдолтой бусад мэдээллээр хангах санаа зорилготой юм.

### **Байгууллагын өмнөөс гуравдагч талын хийсэн төлбөр**

- 2.1.77 *Тайлант үеийн туршид гуравдагч тал нь байгууллагын үүргийг шууд барагдуулах буюу түүний өмнөөс бараа, үйлчилгээг худалдан авахын тулд төлбөр хийсэн гэдгээ уг тайлагнагч байгууллагад албан ёсоор мэдэгдсэн эсвэл ийм төлбөр хийгдсэн гэдгийг тэрхүү байгууллага өөр бусад байдлаар мэдсэн бол тухайн байгууллага нь санхүүгийн тайлангийн тэмдэглэлдээ дараах зүйлсийг тодруулахыг сайшаан дэмжинэ:*

(а) *Ийм гуравдагч талаас хийсэн нийт төлбөр; ба*

(б) *Уг байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой ангиллын суурийг ашиглан хийсэн ийм төлбөрүүдийн нийт дүнгийн дэд ангилал;*

- 2.1.78 Зарим тохиолдолд, гуравдагч тал нь тухайн байгууллагын өмнөөс бараа, үйлчилгээг худалдан авах буюу түүний үүргийг барагдуулдаг. Жишээлбэл; үндэсний засгийн газар нь тухайн тайлант үеийн туршид үйлчилгээ нийлүүлэгчдэд төлбөрийг шууд төлөх эсвэл шаардлагатай хангамжийн зүйлсийг худалдан авч, бусад засгийн газарт шилжүүлэг хийх замаар бие даасан аймгийн буюу хотын захиргааны эрүүл мэндийн болон боловсролын хөтөлбөрийн үйл ажиллагааг санхүүжүүлж болох юм. Үүнтэй адилаар, үндэсний засгийн газар буюу хараат бус тусламжийн агентлаг нь тухайн нэг засгийн газарт зам барьж өгөхдөө мөнгө санг түүнд шууд олгохын оронд, барилгын компанид төлбөрийг шууд төлж болох юм. Эдгээр төлбөрийг буцалтгүй тусламж, хандив буюу бусад туслалцаа, эсвэл эргэн төлөгдөх зээл байдлаар олгож болно. Ийм тохиолдолд аймгийн болон хотын захиргаа нь мөнгийг (үүнтэй дотроо, мөнгөтэй адилтгах хөрөнгийг) шууд хүлээн авахгүй буюу түүний өмнөөс бусад байгууллагын үүсгэн бүрдүүлсэн банкны данс ба түүнтэй адилтгах хэрэгсэлд хяналт тогтоодоггүй. Иймээс түүний өмнөөс барагдуулсан буюу төлсөн дүн нь энэ Стандартад тодорхойлсон “мөнгө”-ийг бүрдүүлэхгүй. Гэвч уг хүлээн авагч засаг захиргаа нь түүний өмнөөс төлсөн мөнгөн зарлагаас өгөөж хүртэж байна.

- 2.1.79 Гуравдагч талаас хийсэн төлбөрийн дүн ба ангиудын талаархи (шинж төрлөөр, чиг үүргээр, эсвэл аль алинаар хийсэн эсэх) мэдээллийн тодруулга нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой нэмэлт мэдээллээр хангадаг. Зарим тохиолдолд тухайн тайлант үеийн туршид байгууллагын өмнөөс гуравдагч талын хийсэн төлбөрийг уг байгууллагад албан ёсоор мэдэгдээгүй, эсвэл байгууллага нь өөр бусад байдлаар мэдээгүй буюу хүлээгдэж буй төлбөр хийгдсэн эсэхийг

шалгах боломжгүй байж болох юм. Гуравдагч талын төлбөрийн талаар тодруулсан дүн нь тайлант үеийн туршид уг байгууллагын өмнөөс хийсэн ийм бүх төлбөрийн үнэн зөв илэрхийлэл эсэхэд тухайн байгууллага нь итгэлтэй биш байвал тэрхүү тодруулга нь гуравдагч талын ийм бүх төлбөрийг агуулаагүй байж болох юм гэдгийг тэмдэглэлдээ дурдаж, хэрэглэгчдэд мэдэгдэх хэрэгтэй.

- 2.1.80 Тайлант үеийн туршид гуравдагч талын хийсэн төлбөрүүдийн нийт дүн ба ийм төлбөрийн гол ангиудын талаар тодруулга хийхийг 2.1.77-р параграфтаар сайшаан дэмжсэн. Гуравдагч талын төлбөр нь энэ Стандартын 2.1.82-р параграфт гадаад тусламж ба бусад тусламж гэж тодорхойлсон дүнгүүдийг агуулна. Гуравдагч талын төлбөр хэлбэрээр байгууллагад үзүүлсэн гадаад тусламжийн дүнгийн талаар тодруулга хийхийг 2.1.90(б) параграфтаар сайшаан дэмжсэн. Практик боломжтой бол бусад тусламжийн талаар мөн ийм тодруулга хийхийг 2.1.91-р параграфтаар сайшаан дэмждэг.
- 2.1.81 2.1.77 параграфын дагуу тодруулж болох гуравдагч талын төлбөрүүдийн дэд ангиллууд нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал юм. Уг шүүн тунгаалтыг хийхдээ харгалзах хүчин зүйлсийг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.17-р параграфт заасан.

## **Гадаадын болон бусад тусламж хүлээн авагчид**

### **Тодорхойлолт**

- 2.1.82 *Дараах нэр томъёог энэ Стандартад доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:*

*Тусламж гэдэг нь гадаад тусламж ба бусад тусламжийг хэлнэ.*

*Гадаадын хоёр талт тусламжийн агентлаг гэдэг нь үндэсний гадаад тусламжийн зорилгоор, үүн дотроо үндэсний бүх буюу зарим гадаад тусламжийг үзүүлэх зорилгоор тухайн үндэсний хууль, зохицуулалт болон үндэсний бусад бүрэн эрхийн дагуу үүсгэн байгуулагдсан агентлаг юм.*

*Арилжааны ажил гүйлгээ гэдэг нь нэг байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах, эсвэл өр төлбөрийг барагдуулах ба үүний хариуд ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлсийг (үндсэндээ мөнгө, бараа, үйлчилгээ буюу хөрөнгө ашиглуулах хэлбэрээр) нөгөө талд шууд өгдөг ажил гүйлгээг хэлнэ.*

*Гадаад тусламж гэдэг нь хүлээн авагч өөрийн зорилгыг биелүүлэхэд ашиглах буюу өөр бусад байдлаар өгөөж хүртэж болох албан ёсны бүх нөөц юм.*

*Гадаадын олон талт тусламжийн агентлаг гэдэг нь гадаад тусламжийн зорилгоор, үүн дотроо гадаад тусламж үзүүлэх зорилгоор олон улсын гэрээ буюу хэлэлцээрийн дагуу үүсгэн байгуулагдсан агентлаг юм.*

*Төрийн бус байгууллага (ТББ) гэдэг нь засгийн газар (газрууд), засгийн газрын агентлагууд, бусад байгууллагууд буюу хувь хүмүүст тусламж үзүүлэх зорилгоор, аливаа засгийн газрын хяналтаас хараат бусаар үүсгэн байгуулсан гадаадын болон үндэсний бүх агентлагууд юм.*

*Албан ёсны нөөц гэдэг нь тусламж олгож буй эсвэл олгохоор амласан засгийн газар болон засгийн газрын агентлагтай нэг ижил улсын биш, тийм хүлээн авагчид заавал биелүүлэх хэлцлийн дагуу гадаадын олон талт буюу хоёрт талт тусламжийн агентлагуудаас, эсвэл засгийн газар буюу засгийн газрын агентлагаас олгосон эсвэл амласан бүх зээл, буцалтгүй тусламж, техникийн тусламж, баталгаа болон бусад тусламж юм.*

*Бусад тусламж гэдэг нь төрийн бус байгууллага (ТББ)-аас олгосон нөөц, түүнчлэн хувь хүмүүс болон хувийн хэвшлийн байгууллагуудаас сайн дураар өгсөн ба хүлээн авагч өөрийн зорилгыг биелүүлэхэд ашиглах буюу өөр бусад байдлаар өгөөж хүртэж болох бэлэг, хандив болон бусад хэлбэрийн тусламж юм. Албан ёсны нөөц, татвар, торгууль, хураамж ба арилжааны ажил гүйлгээгээр бүрдүүлсэн нөөц, тухайн хүлээн авагчтай нэг ижил улсын засгийн газар болон засгийн газрын агентлагуудаас олгосон нөөц нь бусад тусламжид хамаарахгүй.*

## **Тусламж**

- 2.1.83 “Гадаад тусламж” ба “бусад тусламж”-ийг багтаан агуулахын тулд “тусламж”-ийг энэ Стандартад өргөнөөр тодорхойлсон. Гадаад тусламж болон бусад тусламжийн гол шинжүүдийг доор дурдав.

### *Гадаад тусламж*

- 2.1.84 Хүлээн авагч нь өөрийн зорилгыг биелүүлэхэд ашиглах буюу өөр бусад байдлаар өгөөж хүртэж болох албан ёсны бүх нөөц гэж гадаад тусламжийг тодорхойлдог. Янз бүрийн байгууллагууд нь гадаад тусламж буюу гадаад тусламжийн ангиудын хувьд өөр өөр нэр томъёог ашиглаж болох юм. Жишээлбэл; зарим байгууллагууд нь гадаад тусламжийн оронд гадаадын туслалцаа эсвэл туслалцаа гэсэн нэр томъёог ашиглаж болно. Ийм тохиолдолд өөр өөр нэр томъёо нь будлиан үүсгэх магадлал багатай юм. Гэвч өөр зарим тохиолдолд тухайн нэр томъёо нь эрс ялгаатай байж болох юм. Тийм тохиолдолд уг бүрдүүлсэн нөөцийг гадаад тусламж гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо мэргэжлийн шүүн тунгаал хийх шаардлагатай байдаг.
- 2.1.85 Албан ёсны нөөц нь тусламж олгогчтой нэг ижил улсын биш, тийм хүлээн авагчид заавал биелүүлэх хэлцлийн дагуу гадаадын олон талт буюу хоёрт талт тусламжийн агентлагуудаас, эсвэл засгийн газар буюу засгийн газрын агентлагаас олгосон эсвэл амласан нөөц юм. Албан ёсны нөөцийн тодорхойлолтод дурдсан засгийн газар гэдэгт аливаа улсын үндэсний буюу мужийн засгийн газар, бүсийн болон орон нутгийн засаг захиргаа хамаарч болох юм. Иймээс тухайлбал, нэг улсын үндэсний буюу мужийн засгийн газрын агентлагаас нөгөө улсын мужийн буюу орон нутгийн засаг захиргаанд олгох тусламж нь энэ Стандартад тодорхойлсон, гадаад

тусламж болно. Хэдийгээр тусламжийг заавал биелүүлэх хэлцлийн дагуу олгодог боловч нэг улсын үндэсний буюу мужийн засгийн газраас тухайн улсын засгийн газрын бусад түвшинд олгож буй тусламж ба төрийн бус байгууллага (ТББ)-аас олгох тусламж нь албан ёсны нөөцийн тодорхойлолтыг хангахгүй, иймээс гадаад тусламж биш юм.

2.1.86 Гадаад тусламжийн хэлэлцээрээр тухайн байгууллагад дараах нөхцлийг олгож болох юм:

- (а) Зээл буюу буцалтгүй тусламжийн нийт мөнгөн орлогыг, эсвэл уг зээл, буцалтгүй тусламжийн тодорхой хэсгийг мөнгөөр хүлээн авах;
- (б) Зээлийн буюу буцалтгүй тусламжийн хэлэлцээрт заасан, тухайн байгууллагын үүргийг мөнгөөр барагдуулснаар гуравдагч талд тэрхүү байгууллагын төлсөн шалгуур хангах төлбөрийг нөхөн авах; эсвэл
- (в) Зээлийн буюу буцалтгүй тусламжийн хэлэлцээрт заасан, тухайн хүлээн авагч байгууллагын үүргийг, үүн дотроо ТББ-аас авсан буюу авах бараа, үйлчилгээний хувьд тэрхүү хүлээн авагч байгууллагын хүлээх үүргийг мөнгөөр барагдуулж, гуравдагч талд төлбөрийг шууд төлөхийг тус гадаад тусламжийн агентлагаас хүсэх.

Тухайн хүлээн авагчид олгох бараа, үйлчилгээ нь гадаад тусламжийн хэлэлцээрт бас хамаарч болох юм.

#### *Бусад тусламж*

2.1.87 Бусад тусламжийг төрийн бус байгууллага (ТББ)-аас олгосон нөөц, түүнчлэн тухайлбал, хувь хүмүүс, хүмүүнлэгийн болон бусад байгууллагуудаас сайн дураар олгосон тусламж гэж тодорхойлдог. Хууль болон зохицуулалтын дагуу улсын секторын байгууллагуудад албан журмаар төлсөн буюу төлөх татвар ба бусад нөөц, хууль болон зохицуулалтын зөрчилд ногдуулсан торгууль буюу бусад төлбөр, улсын секторын байгууллагуудын үзүүлсэн эсвэл түүний өмнөөс үзүүлсэн үйлчилгээний төлбөр нь 2.1.82-р параграфт тодорхойлсон бусад тусламж биш юм. Үүнтэй адилаар, арилжааны ажил гүйлгээгээр бүрдүүлсэн нөөц, нэг улсын засгийн газрын байгууллагуудын хоорондох нөөцийн шилжүүлэлтийг бусад тусламж гэж ангилахгүй.

2.1.88 Ихэнх тохиолдолд нөөцийг сайн дураар бүрдүүлсэн эсэх, түүний зориулалт нь тухайлбал, гамшгийг арилгах зорилгоор тусламж үзүүлэх, эдийн засгийн хөгжлийн буюу нийгмийн хангамжийн зорилтууд болон бусад зорилгыг биелүүлэхэд уг байгууллагад туслах явдал эсэх нь тодорхой ойлгомжтой байдаг. Гэвч зарим тохиолдолд тухайн бүрдүүлсэн нөөцийг бусад тусламж гэж ангилах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо мэргэжлийн шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг.

2.1.89 ТББ-ууд нь аливаа засгийн газрын хяналтаас хараат бусаар үүсгэн байгуулагдсан гадаадын буюу үндэсний агентлагууд юм. Зарим цөөн тохиолдолд донор байгууллага нь гадаадын хоёр талт буюу олон талт тусламжийн агентлаг, эсвэл ТББ эсэх, иймээс аливаа засгийн газрын



хяналтаас хараат бус эсэх нь тодорхойгүй байж болох юм. Ийм донор байгууллага нь заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүдийн дагуу тусламж үзүүлдэг буюу үзүүлэхээр амалдаг тохиолдолд энэ Стандартад тодорхойлсон албан ёсны нөөц ба ТББ-аас олгосон нөөцийн хоорондох зааг ялгаа бүрхэг байж болно. Ийм тохиолдолд уг хүлээн авсан тусламж нь гадаад тусламжийн эсвэл бусад тусламжийн тодорхойлолтыг хангах эсэхийг тодорхойлохын тулд мэргэжлийн шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг.

### **Хүлээн авсан гадаад тусламж**

2.1.90 *Байгууллага нь санхүүгийн тайлангийн тэмдэглэлдээ дараах зүйлсийг тусад нь тодруулахыг сайшаан дэмжинэ:*

- (a) *Мөнгөн орлого, зарлагын тайланд мөнгөн орлогын тусдаа анги байдлаар тодруулснаас бусад тохиолдолд тухайн тайлант үеийн туршид мөнгөөр хүлээн авсан гадаад тусламжийн нийт дүн;*
- (б) *Гуравдагч талаас мэдэгдсэн эсвэл хүлээн авагч нь өөр бусад байдлаар шалгасан тохиолдолд уг байгууллагын үүргийг шууд барагдуулах буюу түүний өмнөөс бараа, үйлчилгээг худалдан авахын тулд тайлант үеийн туршид гуравдагч талын төлсөн гадаад тусламжийн нийт дүн;*
- (в) *Тухайн тайлант үеийн туршид зээл байдлаар болон буцалтгүй тусламж байдлаар хүлээн авсан гадаад тусламжийн нийт дүн; ба*
- (г) *Гадаад тусламж үзүүлэгчдийн гол ангиуд ба тэдгээрийн өгсөн дүн.*
- (д) *Тухайн тайлант үеийн туршид хүлээн авсан ба ашигласан гадаад тусламжийн гол анги, дүн, зориулалт, үүнд зээл ба буцалтгүй тусламж хэлбэрээр авсан дүнгүүдийг тусдаа харуулах; ба*
- (e) *Тухайн хүлээн авагч ашиглах боломжтой зээл буюу буцалтгүй тусламжийн дүнг заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заасан бөгөөд тэрхүү дүнг ашиглах эсэхийг тодорхойлох буюу түүнд нөлөө үзүүлэх аливаа чухал нөхцөл, болзол биелэгдэх өндөр магадлалтай бол, зөвхөн тийм тохиолдолд ирээдүйн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглах боломжтой ба тайлангийн өдрөөр зарцуулаагүй байгаа гадаад тусламжийн зээл болон буцалтгүй тусламжийн үлдэгдэл, үүнд дараах зүйлсийг тусад нь харуулна:*
  - (i) *Гадаад тусламжийн зээлийн нийт дүн;*
  - (ii) *Гадаад тусламжийн буцалтгүй тусламжийн нийт дүн; ба*
  - (iii) *Зарцуулаагүй тусламжийн зээл ба зарцуулаагүй буцалтгүй тусламжийг ашиглан зарцуулж болох зорилго.*

### **Хүлээн авсан бусад тусламж**

2.1.91 *Практик боломжтой тохиолдолд байгууллага нь дээрх 2.1.90-р параграфт заасан тодруулгыг тухайн хүлээн авсан бусад тусламжид хэрэглэхийг сайшаан дэмжинэ.*

### **Хүлээн авсан гадаадын болон бусад тусламж**

2.1.92 Хүлээн авсан гадаад тусламжийн нийт дүн, түүнчлэн мөнгөн хэлбэрээр болон тухайн байгууллагын өмнөөс гуравдагч талын хийсэн төлбөр хэлбэрээр хүлээн авсан гэдгээр тус тусад нь харуулсан, бусад тусламжийн дүнгийн тодруулга нь тухайн тайлагнагч байгууллагын үйл ажиллагааг татвар ба/буюу дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлдэг хэмжээ, эсвэл гадаад болон бусад тусламжаас түүний хамааралтай хэмжээ, мөнгө эсвэл бусад үр өгөөж эсэх уг тусламжийн хэлбэрийн талаархи ач холбогдолтой мэдээллээр хангадаг. Тайлант үеийн туршид гуравдагч талаас төлбөр хийгдсэн гэдгийг тухайн байгууллагад албан ёсоор мэдэгдсэн буюу төлбөр төлөлтийг өөр бусад байдлаар шалгасан тохиолдолд гуравдагч талын төлбөр хэлбэрээр хүлээн авсан гадаад тусламж болон бусад тусламжийн тодруулга хийхийг сайшаан дэмждэг.

2.1.93 Зээл эсвэл буцалтгүй тусламж хэлбэрээр хүлээн авсан гадаад болон бусад тусламжийн дүнгийн тодруулга нь уг олгосон тусламжийг тухайн байгууллага ирээдүйн тодорхой хугацаанд буцаан төлөх үүрэгтэй эсэхийг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог.

2.1.94 Тухайлбал; олон улсын донорууд, хоёр талт хамтын ажиллагааны донорууд, олон улсын тусламжийн байгууллагууд, ТББ-ууд, үндэсний тусламжийн байгууллагууд гэх мэт тусламж үзүүлэгчдийн гол ангиуд буюу тайлагнагч байгууллагад тохиромжтой бусад гол ангиудын тодруулга нь тодорхой төрлийн хандивлагчдаас уг байгууллага хараат байх хэмжээг тодорхойлдог бөгөөд тухайн тусламжийн тогтвортой байдлын үнэлгээнд ач холбогдолтой байдаг.

2.1.95 Байгууллага нь олон зорилгоор, үүн дотроо өөрийн дараах зүйлсийг дэмжихийн тулд гадаад тусламжийг хүлээн авч болно:

- (а) Эдийн засгийн хөгжил болон нийгмийн хамгааллын зорилтууд, эдгээрийг ихэвчлэн хөгжлийн тусламж гэж нэрлэдэг;
- (б) Яаралтай арга хэмжээний зорилтууд, эдгээрийг ихэвчлэн яаралтай тусламж гэж нэрлэдэг;
- (в) Төлбөрийн тэнцлийн байдал, эсвэл өөрийн валютын ханшийг хамгаалах, эдгээрийг ихэвчлэн төлбөрийн тэнцлийн тусламж гэж нэрлэдэг;
- (г) Цэргийн ба/буюу батлан хамгаалах зорилтууд, эдгээрийг ихэвчлэн цэргийн тусламж гэж нэрлэдэг; ба
- (д) Худалдааны үйл ажиллагаа, үүн дотроо экспортын зээл эсвэл экспорт/импортын банкууд буюу засгийн газрын бусад

агентлагуудаас санал болгодог зээл, эдгээрийг ихэвчлэн худалдааны санхүүжилт гэж нэрлэдэг.

- 2.1.96 Бусад тусламжийг дээрх зарим зорилтын хувьд тухайлбал, яаралтай арга хэмжээний зорилтууд ба тухайн байгууллагын нийгмийн хамгааллын зорилтуудад дэмжлэг үзүүлэхийн тулд бас олгож болно.
- 2.1.97 Тайлант үеийн туршид гадаадын болон бусад тусламжийг олгосон ба ашиглан зарцуулсан зорилгын гол ангиар хийсэн тодруулга нь хүлээн авсан тусламжийг ашиглах уг байгууллагын хариуцлагатай байдлыг цаашид сайжруулах юм.
- 2.1.98 Заавал биелүүлэх хэлцлийн дагуу одоогоор амласан боловч хараахан зарцуулаагүй байгаа гадаад тусламжийн, түүнчлэн ТББ болон бусад эх үүсвэрээс авах тусламжийн дүн нь мэдэгдэхүйц их хэмжээтэй байж болно. Зарим тохиолдолд тусламжийн зээл буюу буцалтгүй тусламжийн дүнг заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заадаг бөгөөд тухайн дүнг ашиглахын тулд хангах шаардлагатай аливаа мэдэгдэхүйц нөхцлүүд биелэх өндөр магадлалтай байдаг. Тухайн нөхцлүүд хангагдсан ба цаашид хангагдсан хэвээр байх одоо хэрэгжиж буй төслүүд, түүнчлэн хэлцлийн нөхцлийн дагуу үргэлжлэхээр урьдчилан таамагласан төслийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийн хувьд ийм тохиолдол үүсэж болно. Ийм нөхцөлд гадаадын болон бусад тусламжийн зарцуулаагүй үлдэгдлийн талаархи тодруулга нь уг байгууллагад олгох бэлэн боломжтой байгаа тусламжаас тухайн тайлант үеийн туршид зарцуулсан хэмжээ, түүнчлэн тодорхой төслүүдийн тасралтгүй хөгжүүлэлтийг дэмжихийн тулд олгохоор амласан гадаадын болон бусад тусламжийн дүнгийн талаархи мэдээллээр хангадаг.
- 2.1.99 Зарим тохиолдолд донор байгууллага нь тухайн тайлагнагч байгууллагад үргэлжлүүлэн тусламж үзүүлэх санаа зорилготой байгаагаар илэрхийлсэн боловч ирээдүйн тайлант үеүдэд олгох уг тусламжийн зээл (зээлүүд) буюу буцалтгүй тусламжийн (тусламжуудын) дүнг заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заагаагүй байж болох юм. Өөр зарим тохиолдолд тусламжийн дүнг тусгайлан заасан боловч биелэх өндөр магадлалтай гэж тухайн тайлангийн өдрөөр үнэлж чадахааргүй тийм нөхцөл, болзолтой байж болно. Ийм тохиолдолд уг зарцуулаагүй дүнгийн талаар тодруулга хийхийг 2.1.90(е) параграфар сайшаан дэмжээгүй. Зарим тохиолдолд гадаад тусламжийг ашиглаж болох эсэхийг тодорхойлох буюу түүнд нөлөө үзүүлэх чухал нөхцөл, болзлын биелэлт өндөр магадлалтай эсэхийг үнэлэхдээ мэргэжлийн шүүн тунгаалт хийх шаардлагатай байж болно.

### **Хүлээн авсан бараа, үйлчилгээ**

- 2.1.100 *Байгууллага нь тайлант үеийн туршид бараа, үйлчилгээ хэлбэрээр хүлээн авсан тусламжийн үнэ цэнэ болон уг үнэ цэнийг тодорхойлсон суурийг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусад нь тодруулахыг сайшаан дэмжинэ.*

- 2.1.101 Мэдэгдэхүйц хэмжээний нөөцийг бараа, үйлчилгээ хэлбэрийн тусламж байдлаар хүлээн авч болох юм. Авто тээврийн хэрэгсэл, компьютер, бусад тоног төхөөрөмж гэх мэт шинэ буюу хуучин барааг гадаад тусламжийн хэлэлцээрийн дагуу, эсвэл тухайлбал, ТББ болон хувийн хэвшлийн хандивлагчдаас тухайн байгууллагад шилжүүлснээр ийм тохиолдол үүсдэг. Гадаад тусламжийн хэлэлцээрийн дагуу эсвэл ТББ болон бусад доноруудаас гамшгийн үеийн туслалцаа байдлаар иргэдэд тараах зорилгоор засгийн газарт хүнсний туслалцаа үзүүлэх үед мөн ийм тохиолдол гардаг. Зарим хүлээн авагчдын хувьд, бараа буюу үйлчилгээ нь тусламж хүлээн авах гол хэлбэр байж болох юм.
- 2.1.102 Тайлант үеийн туршид бараа, үйлчилгээ байдлаар хүлээн авсан тусламжийн үнэ цэнийн тодруулга нь тухайн тайлант үеийн туршид хүлээн авсан тусламжийн нийт хэмжээг илүү сайн олгоход санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тусалдаг. Гэвч зарим тохиолдолд болон зарим хүлээн авагчдын хувьд ийм бараа, үйлчилгээний үнэ цэнийг тодорхойлох нь төвөгтэй, цаг хугацаа их зарцуулсан, өртөг зардалтай үйл явц байж болно. Тухайн бараа, үйлчилгээний дотоодын зах зээлийн үнийг шууд тодорхойлж чадахгүй, нийлүүлсэн бараа, үйлчилгээг олон улсын зах зээлд арилждаггүй буюу яаралтай тусламжийн хувьд ихэвчлэн олгодог гэх мэт өвөрмөц онцлогтой бол ялангуяа ийм тохиолдол үүсдэг.
- 2.1.103 Бараа, үйлчилгээний үнэ цэнийг тодорхойлох суурийг энэ Стандартад тусгайлан заагаагүй. Иймээс тэдгээрийн үнэ цэнийг тухайн хөрөнгийг хүлээн авагчид шилжүүлэх үеийн биет хөрөнгийн элэгдэл тооцсон түүхэн өртгөөр, эсвэл хүнсний хувьд гадаад тусламжийн агентлаг болон бусад донорын төлсөн үнээр тодорхойлж болох юм. Шилжүүлэгчийн удирдлагын, эсвэл хүлээн авагчийн, эсвэл гуравдагч талын үнэлгээнд үндэслэн үнэ цэнийг бас тодорхойлж болно. Бараа, үйлчилгээ хэлбэрийн тусламжийн үнэ цэнийг тодруулдаг тохиолдолд уг үнэ цэнийг тодорхойлдог суурийг тодруулахыг 2.1.100-р параграфтаар сайшаан дэмжсэн. Бодит үнэ цэнэ гэж илэрхийлдэг тохиолдолд энэ нь бодит үнэ цэнийн тодорхойлолттой нийцдэг өөрөөр хэлбэл, зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийг арилжиж, өр төлбөрийг барагдуулж болох дүн байна.

## **2.2 Санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжиж буй засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагууд**

### **Мөнгөн орлого, зарлагын тайлангийн толилуулга**

- 2.2.1 *Санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжиж буй буй байгууллага нь мөнгөн орлого, зарлагын тайлангаа Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт 2 (УСНББОУС 2) “Мөнгөн Гүйлгээний Тайлан”-гаар шаардсантай ижил загвараар толилуулахыг сайшаан дэмжинэ.*

- 2.2.2 Аккруэл УСНББОУС-ыг албан ёсоор мөрдөхөөс өмнө байгууллагууд нь одоо үйлчилж байгаа аккруэл УСНББОУС нэг бүрийг даган мөрдөхөд шаардлагатай мэдээлэл болон системийг санхүүгийн тайлагналын аккруэл суурьт шилжихийн хэрээр аажмаар бүрдүүлэх шаардлагатай юм. Аккруэл УСНББОУС-д хэрэглэдэг хэлбэр загварыг аль болох боломжит хэмжээгээр орлох тийм хэлбэр загвараар мэдээллийг толилуулах нь шилжилтийн үйл явцад туслалцаа үзүүлнэ.
- 2.2.3 УСНББОУС 2 нь мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны гэж ангилах заавар удирдамжаар хангадаг бөгөөд эдгээр ангиудыг уг тайланд тус тусад нь тайлагнах мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэх шаардлагуудыг агуулсан байдаг. УСНББОУС 2-ын гол төлөв хандлагуудын тойм болон тус Стандартын дагуух санхүүгийн тайлагналд түүнийг мөрдөх талаархи заавар удирдамжийг Хавсралт 3-д тусгасан. УСНББОУС 2-оор шаардсанаас бусад, нэмэлт мэдээллийн тодруулга хийхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн. Мөнгөн орлого, зарлагын тайлангийн толилуулгад УСНББОУС 2-ын загварыг баримталдаг байгууллагууд нь энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт заасан, нэмэлт тодруулга хийхийг мөн дэмжинэ.

### **Нэгтгэсэн санхүүгийн тайлан – Эдийн засгийн нэгдмэл байгууллага**

- 2.2.4 Хяналт тавигч байгууллагууд нь хяналтанд буй бүх байгууллагуудаа нийтээр хүлээн зөвшөөрсөн нэгтгэлийн үйл явцын дагуу нэгтгэсэн, тийм нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулах ба ингэж нэгтгэх шаардлагагүй байж болох зарим нөхцөл байдлыг тодорхойлохыг энэхүү Стандартаар сайшаан дэмждэг. Тэдгээр нөхцөл байдлууд нь УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-д дурдсан, нөхцлүүдийг тусгасан байдаг. Гэхдээ УСНББОУС 35 нь хөрөнгө оруулалтын байгууллага бөгөөд өөрийн хяналтанд буй байгууллагуудыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг тийм хяналт тавигч байгууллагыг нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх шаардлагаас чөлөөлөх нэмэлт нөхцлүүдийг агуулсан байдаг. Энэхүү чөлөөлөх нөхцөл нь хөрөнгө оруулалтын байгууллага боловч Мөнгөн суурьт УСНББОУС-ыг мөрддөг тийм хяналт тавигч байгууллагуудад хамаарахгүй юм.
- 2.2.5 Хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэсэн, тийм санхүүгийн тайлан толилуулдаггүй тохиолдолд төсвийн сектор, засгийн газрын үндсэн сектор буюу засгийн газрын гол үйл ажиллагааны бусад төлөөллийг тусгасан гэх мэт хяналтанд буй байгууллагуудын дэд бүлгүүдээс бүрдэх эдийн засгийн нэгдмэл байгууллагын талаархи мэдээллийг толилуулдаг тийм санхүүгийн тайлан бэлтгэхийг энэ Стандартаар сайшаан дэмжсэн. Аккруэл УСНББОУС нь ийм эдийн засгийн нэгдмэл байгууллагын талаархи мэдээллийн толилуулгыг хориглодоггүй боловч УСНББОУС 35-д дурдсан, хяналтанд буй бүх байгууллагуудын бүрэн нэгтгэлийн хувилбар байдлаар түүнийг толилуулж болохгүй юм.

- 2.2.6 Санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжиж буй байгууллагууд нь аккруэл ба мөнгөн суурьт УСНББОУС-уудын нэгтгэлийн шаардлагуудын энэхүү ялгаатай байдлыг мэддэг байх шаардлагатай.

### **Мөнгөн суурьт УСНББОУС-ын дагуу шаардсан ба дэмжсэн тодруулга**

- 2.2.7 Мөнгөн суурьт санхүүгийн тайлагналд мөрддөг тохиолдолд энэхүү Стандартын шаардлагууд ба сайшаан дэмжилтийг адилтгах аккруэл УСНББОУС-ын шаардлагууд болон сайшаан дэмжилттэй зөрчилддөг гэж үзэхгүй. Гэвч зарим тохиолдолд энэ Стандарт нь аккруэл УСНББОУС-аар шаардаагүй тийм тодруулгыг сайшаан дэмжсэн байдаг. Тухайлбал; гуравдагч талын төлбөр, гадаадын болон бусад тусламж гэх мэт асуудлуудын талаар сайшаан дэмжсэн тодруулгын хувьд ийм тохиолдол гардаг. Байгууллага нь хэрхэн нөөцөө бүрдүүлсэн гэдгийг үнэлэхэд ач холбогдолтой нэмэлт мэдээллээр хангахын тулд тэдгээр тодруулгыг энэхүү Стандартад сайшаан дэмждэг. Ийм мэдээлэл нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн бүх хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг. Энэ нь тухайлбал, байгууллагад үзүүлэх тусламж ба түүний зарцуулалтыг хянан үнэлэхэд ач тустай мэдээллийн хувьд гадаадын болон бусад тусламж үзүүлэгчдийн “тусгай зорилго” бүхий хэрэгцээ шаардлагад хамааралтай байж болох юм.

### **УСНББОУС 33, Аккруэл Суурьт УСНББОУС-ыг Анх Удаа Мөрдөх**

- 2.2.8 Аккруэл УСНББОУС-ыг анх мөрдсөн өдрөөс хойш гурван (3) жилийн хугацаанд уг аккруэл УСНББОУС-ын зарим шаардлагуудын мөрдөлтөөс байгууллагуудыг чөлөөлөх тийм шилжилтийн нөхцлүүдийг УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д заасан. УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөр уг анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС 33-д заасан, нэг буюу хэд хэдэн чөлөөлөх нөхцлүүдийг мөрдөх сонголт хийж болох бөгөөд баримталсан чөлөөлөх нөхцлүүдийн шинж төрлөөс хамааран өөрийн санхүүгийн тайланг дараах аль нэг байдлаар тодорхойлно гэж УСНББОУС 33-д дурдсан:

- (а) *Шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан*, энэ нь “Үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх чөлөөлөх нөхцлүүд” байдлаар УСНББОУС 33-д тодорхойлсон тэдгээр чөлөөлөх нөхцлүүдийг мөрддөг тохиолдол юм;
- (б) *Аккруэл суурьт УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан*, энэ нь УСНББОУС 33-д тодорхойлсон бусад чөлөөлөх нөхцлүүдийг мөрддөг тохиолдол юм. Өөрөөр хэлбэл, энэ нь “Үнэн зөв толилуулга ба

аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй чөлөөлөх нөхцлүүд” юм<sup>3</sup>.

- 2.2.9 Анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ын мөрдөлтөнд хэрэглэх шаардлагатай ба/буюу хэрэглэхээр сонгосон шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон болзлуудыг УСНББОУС 33-ын Хавсралт А-д жагсаан харуулсан, түүнчлэн үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-д нийцсэн гэж мэдэгдэх уг анх удаа мөрдөж буй байгууллагын чадвар боломжид нөлөөлөх эсэхийг энд үлгэрчлэн харуулсан.

---

<sup>3</sup> Анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ын мөрдөлтөнд хэрэглэх шаардлагатай ба/буюу хэрэглэхээр сонгосон шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд болон болзлуудыг УСНББОУС 33-ын Хавсралт А-д жагсаан харуулсан, түүнчлэн үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-д нийцсэн гэж мэдэгдэх уг анх удаа мөрдөж буй байгууллагын чадвар боломжид нөлөөлөх эсэхийг энд үлгэрчлэн харуулсан.

## **Дүгнэлтийн үндэслэл – Мөнгөн суурьт УСНББОУС-ын Хоёрдугаар хэсэг**

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС, “Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал”-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Оршил – Энэхүү УСНББОУС-ын мөрдөлтөнд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах**

- ДҮ1. Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-ын Нэгдүгээр хэсэгт өмнө нь тусгаж байсан, нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэлтийн болон гадаадын тусламж, гуравдагч талын төлбөрийн талаархи мэдээллийн тодруулгын шаардлагуудыг энэхүү Стандартын мөрдөлтөнд тулгарч буй гол саад бэрхшээл гэж үзсэн. Эдгээр саад бэрхшээлийг арилгахын тулд уг шаардлагуудыг хянан засварлаж, энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжилт байдлаар дахин оруулсан.
- ДҮ2. Эдгээр шаардлагуудыг сайшаан дэмжилт байдлаар дахин оруулах явцдаа, санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжихэд нь дэмжлэг үзүүлэх үүднээс энэ Стандартын Хоёрдугаар хэсгийн үүргийг нэмэгдүүлэхийн тулд нэмэлт засвар, өөрчлөлтүүдийг хийсэн.

### **Нэгтгэл**

- ДҮ3. Хяналт тавигч байгууллагууд нь хяналтанд буй бүх байгууллагуудаа нэгтгэн тусгах тийм нэгтгэсэн санхүүгийн тайлан толилуулахыг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн. Хяналтанд буй бүх байгууллагуудаа нэгтгэдэггүй, хяналт тавигч байгууллагууд нь төсвийн сектор, засгийн газрын үндсэн сектор буюу засгийн газрын гол үйл ажиллагааны бусад төлөөллийг илэрхийлэх эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжих завсрын алхам байдлаар бэлтгэхийг мөн сайшаан дэмжсэн. Ийм санхүүгийн тайлан нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллээр хангах ба аккруэл УСНББОУС-аар шаардсан бүрэн нэгтгэлд дэс дараалалтай, зохих ёсоор шилжихэд дэмжлэг үзүүлнэ. Засгийн газрын үндсэн секторыг төлөөлөн илэрхийлэх хяналтанд буй байгууллагуудаас бүрдсэн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд санхүүгийн тайланг толилуулах уг сайшаан дэмжилт нь тохиромжтой тохиолдолд улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандартууд ба санхүүгийн тайлагналын статистикын сууриудын уялдааг дэмжих УСНББОУС3-ийн стратегийн зорилттой бас нийцдэг.
- ДҮ4. Аккруэл суурьт шилжиж буй байгууллагуудад цаашид дэмжлэг үзүүлэхийн тулд гол тодорхойлолтууд болон сайшаан дэмжсэн тодруулгууд нь УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн*



*Санхүүгийн Тайлан, УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт, УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр, УСНББОУС 38, Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-тай зөрчилдөөгүй гэдгийг ханган магадлахад шаардлагатай хэмжээгээр тэдгээр тодорхойлолт, сайшаан дэмжсэн тодруулгыг хянан засварласан.

## **Гадаад тусламж**

- ДҮ5. Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-ын Нэгдүгээр хэсэгт тусгаж байсан, гадаад тусламжийн талаархи мэдээллийг тодруулах шаардлагуудыг хянан засварлаж, тус Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжилт байдлаар буцаан оруулсан. Түүнчлэн, өмнө нь шаарддаг буюу сайшаан дэмждэг байсан тодруулгуудыг багасгаж, тухайн тайлант үеийн туршид мөнгө ба гуравдагч талын төлбөр хэлбэрээр хүлээн авсан болон зарцуулсан гадаад тусламж, мөн тайлангийн өдрөөр уг тайлагнагч байгууллагад бэлэн боломжтой байгаа зарцуулаагүй тусламжийн дүнгийн талаархи мэдээллийн тодруулга хийх сайшаан дэмжилтээр үндсэндээ хязгаарласан. Энэхүү хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017) нь гадаад тусламжийн хэлцлийн гол нөхцөл ба болзол, даган биелүүлээгүй нөхцөл ба болзол, төлөөгүй байгаа гадаад тусламжийн өрийг буцаан төлөх нөхцөл ба болзол гэх мэт асуудлуудын талаархи мэдээллийн тодруулгыг тус Стандартаас хасахыг мөн сайшаан дэмжсэн. Тайлагнагч байгууллага нь тухайлбал, ТББ, төрийн болон хувийн хэвшлийн донор байгууллагуудаас мөнгө ба гуравдагч талын төлбөр хэлбэрээр түүнд олгосон тусламжийн талаар тодруулга хийхийг энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт практик боломжтой хэмжээгээр сайшаан дэмждэг.
- ДҮ6. Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой мэдээллээр хангадаг уг сайшаан дэмжсэн тодруулгуудыг хийх илүү их магадлалтай бөгөөд мөнгөн суурьт санхүүгийн тайланд хамаарах ерөнхий зорилгын шинж төрлийг илүү сайн тусгана гэж УСНББОУСЗ үздэг.
- ДҮ7. Тайлант үеийн туршид гадаадын тусламж хэлбэрээр хүлээн авсан бараа, үйлчилгээний үнэ цэнийн тодруулга хийхийг Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-ын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн. Байгууллага нь тайлант үеийн туршид бараа, үйлчилгээ хэлбэрээр хүлээн авсан гадаадын тусламжийн үнэ цэнийг тодруулах сонголт хийсэн тохиолдолд уг үнэ цэнийг тодорхойлсон суурийг мөн тодруулахыг тус Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-ын Нэгдүгээр хэсэгт шаардсан байдаг. ТББ-аас авсан тусламжийн хувьд ийм тодруулга хийхийг сайшаан дэмждэг боловч заавал шаарддаггүй. Зарим сонгогч иргэд нь гуравдагч талын төлбөртэй холбоотой эдгээр шаардлагууд ба сайшаан дэмжилтийн хоорондох уялдаа холбоог тодорхой болгохыг хүссэн. Бараа, үйлчилгээг гадаад тусламжийн хэлцлийн дагуу албан ёсны нөөц байдлаар хүлээн авсан тохиолдолд уг бараа, үйлчилгээний үнэ цэнийг тодорхойлсон суурийн талаар тодруулга хийхийг шаарддаг боловч бусад нөхцөл байдалд зөвхөн сайшаан дэмжиж байгаад санаа зовж буйгаа зарим сонгогч иргэд бас илэрхийлсэн. УСНББОУСЗ нь эдгээр санаа зовж буй асуудлуудад хариулт өгсөн. Гадаад тусламж ба гуравдагч талын төлбөрийн хоорондох уялдаа холбоог энэхүү

хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017)-д тодруулсан бөгөөд тухайн хүлээн авсан бараа, үйлчилгээний үнэлгээний суурийг тодруулах шаардлагыг энэхүү УСНББОУС-ын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжилт байдлаар дахин оруулсан ба бараа, үйлчилгээ хэлбэрээр хүлээн авсан гадаадын болон бусад тусламжид мөрдөхөөр цар хүрээг өргөжүүлсэн.

### **Гуравдагч талын төлбөр**

ДҮ8. Гуравдагч талын төлбөрийн талаархи зарим мэдээллийн тодруулгыг мөнгөн орлого, зарлагын тайланд тусдаа багана байдлаар толилуулахыг Мөнгөн суурьт УСНББОУС (2007)-ын Нэгдүгээр хэсэгт шаардсан байдаг. Ийм тодруулгыг санхүүгийн тайланд биш, харин санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тусгахын тулд энэхүү хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017)-д түүнийг сайшаан дэмжилт байдлаар дахин оруулсан. Шаардлагууд буюу сайшаан дэмжилтийг бүрэн биелүүлэхэд хэрэгцээтэй мэдээлэл нь тусламж хүлээн авагчдад тухайн цаг хугацаанд бэлэн боломжтой байдаггүй гэсэн шалтгааны улмаас гуравдагч талын төлбөрийн талаархи мэдээллийг тодруулах уг шаардлагыг сайшаан дэмжилт байдлаар дахин оруулсан. Ийм тохиолдолд санхүүгийн тайланд тусгасан мэдээлэл нь иж бүрэн бус байх магадлалтай бөгөөд хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд түүний ач холбогдлыг буруу тайлбарлах боломжит байдал нь тухайн санхүүгийн тайланд тусдаа баганад түүнийг тодруулахыг зөвтгөн батлахгүй юм.

ДҮ9. Нэг данс хэлбэрийн хэлцэл нь гуравдагч талын төлбөр үүсэхэд хүргэхгүй гэсэн УСНББОУС3-ийн байр суурийг тусгахын тулд ийм хэлцлийн талаар нэмэлт тайлбар оруулах үүднээс энэхүү хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017)-аар Нэгдүгээр хэсэгт мөн өөрчлөлт оруулсан. Энэхүү тайлбар нь гуравдагч талын төлбөр үүсэж болох нөхцөл байдлуудыг хязгаарлах юм.

### **Санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжиж буй байгууллагуудад дэмжлэг үзүүлэх нэмэлт өөрчлөлтүүд**

ДҮ10. Энэхүү хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017) нь санхүүгийн тайлагналын аккруэл суурь ба аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжиж буй засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагуудад дэмжлэг үзүүлэх уг Стандартын үүргийг бэхжүүлэх үүднээс түүний Хоёрдугаар хэсэг дэх сайшаан дэмжилтүүдэд сайжруулалт хийсэн. Эдгээр сайжруулалтанд дараах зүйлс хамаарна:

- (a) Энэ Стандарт дахь мөнгөн суурийн анхаарах зүйлсийг тусгах санаа зорилготой байхаас бусад тохиолдолд адилтгах аккруэл УСНББОУС-тай зөрчилдөөгүй гэдгийг ханган магадлахын тулд шинэчлэн баяжуулсан тодорхойлолт ба сайшаан дэмжсэн тодруулгууд; ба
- (б) Анх мөрдсөн өдрөөс хойш 3-н жилийн хугацаанд аккруэл УСНББОУС-ын зарим шаардлагуудын мөрдөлтөөс чөлөөлөх нөхцөл олгох

*УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-ийн үүргийг тодорхойлох.*

ДҮ11. Санхүүгийн тайлагналын аккруэл суурь ба аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжиж буй байгууллагуудад дэмжлэг үзүүлэх энэ Стандартын Хоёрдугаар хэсгийн үүрэгт нийцүүлэн энэхүү Стандартад тусгасан, хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолтуудыг аккруэл УСНББОУС-д заасан, эдгээр тодорхойлолттой ижил болгосон. Үндсэндээ ижил шинж чанартай боловч “Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал” (Онолын Үзэл Баримтлал)-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын гол шинж чанарыг тодорхой болгох үүднээс тэдгээр тодорхойлолтыг цаашид боловсронгуй болгосон. Онолын Үзэл Баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолтыг тусгах үүднээс уг аккруэл УСНББОУС-ыг хараахан шинэчлэн баяжуулаагүй байгаа, иймээс энэ Стандарт дахь тодорхойлолт нь Онолын Үзэл Баримтлалын тодорхойлолтыг тусгаагүй болно.

*Онцгой шинжтэй зүйлс*

ДҮ12. Энэхүү хянан засварласан Мөнгөн суурьт УСНББОУС (2017) нь онцгой шинжтэй зүйлсийн талаархи мэдээллийн тодруулга, түүнчлэн дэмжих тодорхойлолт ба тайлбарыг сайшаан дэмжихгүй болсон. Өмнөх Мөнгөн суурьт УСНББОУС-ыг гаргах үед хүчин төгөлдөр байсан УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Топилуулга* (2000 онд гаргасан) нь онцгой шинжтэй зүйлсийн талаар санхүүгийн тайланд зарим тодруулга хийхийг шаарддаг байсан. УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан* (2000 онд гаргасан) ба УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* (2000 онд гаргасан) нь онцгой шинжтэй зүйлсийн талаар тусдаа тодруулга хийхийг бас шаарддаг. Гэвч эдгээр шаардлагуудыг аккруэл УСНББОУС-аас одоо хассан. Аккруэл УСНББОУС нь онцгой шинжтэй зүйлсийн талаар тодруулга хийхийг шаарддаггүй, сайшаан дэмждэггүй, хориглодоггүй. Энэ Стандартын Хоёрдугаар хэсгийг аккруэл УСНББОУС-тай нийцүүлэхийн тулд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг хийсэн.

## Хавсралт 2

### Энэ Стандартын Хоёрдугаар хэсэгт сайшаан дэмжсэн зарим тодруулгын үлгэрчилсэн жишээ

Энэхүү Хавсралт нь зөвхөн үлгэрчилсэн жишээ юм. Хавсралтын зорилго нь сайшаан дэмжсэн зүйлсийг хэрхэн мөрдөхийг үлгэрчлэн харуулах ба тэдгээрийн утгыг тодруулахад туслах явдал юм.

#### Засгийн газрын “АБВ” байгууллагын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс

Туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээ (2.1.6-р параграф)

Туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээ нь засгийн газар болон засгийн газрын тодорхой этгээдийн өмнөөс агент байдлаар уг байгууллагын туслалцаа үзүүлсэн ажил гүйлгээний үр дүн болох мөнгөн гүйлгээнээс бүрддэг. Агентын бүрэн эрхийн хүрээнд цуглуулсан бүх мөнгийг нэгтгэсэн орлогын санд ба/буюу итгэмжлэлийн сангийн (дансны нэр) аль тохиромжтойд байршуулдаг. Байгууллага нь эдгээр дансыг хянадаггүй бөгөөд түүнд байршуулсан мөнгийг засгийн газрын холбогдох этгээдийн тусгай зөвшөөрөлгүйгээр ашиглаж болохгүй.

(мянган валютын нэгжээр)	Ажил гүйлгээний шинж төрөл	200X	200X-1
Засгийн газар/засаглах эрхийн өмнөөс цуглуулсан мөнгө	Татварын цуглуулалт	X	X
“И Эф” агентлаг	Ашиглалтын үйлчилгээний төлбөрийн цуглуулалт	X	X
Холбогдох байгууллагуудад шилжүүлсэн мөнгө		X (X)	X (X)
		-	-

#### Холбоотой талуудын ажил гүйлгээ (параграф 2.1.22)

“АБВ” байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт УСНББОУС 20, “Холбоотой Талуудын Тодруулга”-д тодорхойлсноор) нь Сайд, удирдах зөвлөлийн гишүүд, дээд түвшний удирдлагын бүлгийн гишүүд юм. Удирдах зөвлөл нь нь “А” засгийн газраас томилсон гишүүдээс бүрддэг. Гүйцэтгэх захирал болон санхүүгийн албаны дарга нь удирдах зөвлөлийн хуралд оролцдог боловч удирдах зөвлөлийн гишүүд биш юм. “АБВ” байгууллага нь Сайдад цалин урамшуулал олгодоггүй. Удирдах зөвлөлийн гишүүдийн нийт цалин урамшуулал ба энэхүү ангиллын хүрээнд цалин урамшуулал авдаг, бүтэн цагтай адилтгах сууриар тодорхойлсон гишүүдийн тоо дараах байдалтай байна:

Нийт цалин урамшуулал            АХ сая.  
Хүмүүсийн тоо                        АУ хүн.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Дээд түвшний удирдлагын бүлэг нь уг байгууллагын гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга болон хэлтсийн дарга нараас бүрддэг. Дээд түвшний удирдлагын бүлгийн гишүүдийн нийт цалин урамшуулал ба энэхүү ангиллын хүрээнд цалин урамшуулал авдаг, бүтэн цагтай адилтгах сууриар тодорхойлсон менежерүүдийн тоо дараах байдалтай байна:

Нийт цалин урамшуулал            AP сая.  
Хүмүүсийн тоо                        AQ хүн.

**“Х” Засгийн газар: “Х” засгийн газрын Нэгтгэсэн мөнгөн орлого, зарлагын тайлан ба “Х” засгийн газрын санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс**

**“Х” засгийн газар: 200X оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Нэгтгэсэн мөнгөн орлого, зарлагын тайлан (2.1.37-р параграф)  
(Мөнгөн орлого)**

(мянган валютын нэгжээр)	Тод- руулга	200X Орлого/ (Зарлага)	200X-1 Орлого/ (Зарлага)
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>			
<b><i>Татвар</i></b>			
Орлогын албан татвар		X	X
Нэмэгдсэн өртгийн албан татвар		X	X
Үл хөдлөх хөрөнгийн татвар		X	X
Бусад татвар		<u>X</u>	<u>X</u>
		X	X
Гадаадын болон бусад тусламж	E	X	X
<b><i>Зээл</i></b>			
Авсан зээлийн мөнгөн орлого:			
Арилжааны санхүүгийн байгууллагаас		X	
Хөгжлийн банкууд ба адилтгах байгууллагуудаас		X	
<b><i>Капитал мөнгөн орлого</i></b>			
Үндсэн хөрөнгийн данснаас хасалтын мөнгөн орлого		X	X
Санхүүгийн хэрэглүүрийн данснаас хасалтын мөнгөн орлого		X	X
<b><i>Худалдаа арилжааны үйл ажиллагаа</i></b>			
Худалдаа арилжааны үйл ажиллагааны мөнгөн орлого		X	X
<b><i>Бусад мөнгөн орлого</i></b>			
		<u>X</u>	<u>X</u>
<b>Нийт мөнгөн орлого</b>		<u><b>X</b></u>	<u><b>X</b></u>

**“Х” засгийн газар: 200Х оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон  
жилийн Нэгтгэсэн мөнгөн орлого, зарлагын тайлан  
(Мөнгөн зарлага)**

(мянган валютын нэгжээр)	Тод- руулга	200Х Орлого/ (Зарлага)	200Х-1 Орлого/ (Зарлага)
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>			
<b><i>Үйл ажиллагаа</i></b>			
Цалин, хөлс ба ажиллагчдын тэтгэмж		(X)	(X)
Хангамжийн болон хэрэглээний зүйлс		<u>(X)</u>	<u>(X)</u>
		(X)	(X)
<b><i>Шилжүүлэг</i></b>			
Буцалтгүй тусламж		(X)	(X)
Бусад шилжүүлгийн төлбөр		<u>(X)</u>	<u>(X)</u>
		(X)	(X)
<b><i>Капитал зарлага</i></b>			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт/барьж байгуулалт		(X)	(X)
Санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалт		<u>(X)</u>	<u>(X)</u>
		(X)	(X)
<b><i>Зээл ба хүүний буцаан төлөлт</i></b>			
Зээлийн буцаан төлөлт		(X)	(X)
Хүүний буцаан төлөлт		<u>(X)</u>	<u>(X)</u>
		(X)	(X)
<b><i>Бусад төлбөр</i></b>			
		(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлага</b>		<u>(X)</u>	<u>(X)</u>
<b>Мөнгөний өсөлт/(бууралт)</b>		<b>X</b>	<b>X</b>
<b>Мөнгөний жилийн эхний үлдэгдэл</b>		<b>X</b>	<b>X</b>
<b>Мөнгөний өсөлт/(бууралт)</b>		<b>X</b>	<b>X</b>
<b>Мөнгөний жилийн эцсийн үлдэгдэл</b>		<b>X</b>	<b>X</b>

**“Х” засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэл**

(Сайшаан дэмжсэн тодруулгуудыг үлгэрчлэн харуулах хэсгүүд)

**Тэмдэглэл А: Хяналтанд буй байгууллагууд (2.1.53-р параграф)**

“ХҮЗ” байгууллага нь хяналтанд буй байгууллагууд дахь өөрийн оролцооноос бий болох хувьсах өгөөжийг хүртэх эрхтэй бөгөөд тэдгээр байгууллагуудад тавих бүрэн эрхээрээ дамжуулан уг өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөөлөх чадвар боломжтой юм. Хяналтанд буй бүх байгууллагуудыг уг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгадаг. Хяналтанд буй томоохон байгууллагуудыг доор тодорхойлов.

<u>Хяналтанд буй томоохон байгууллагууд</u>	<u>Улс</u>
“А” Байгууллага	
“Б” Байгууллага	
“В” Байгууллага	X
“Г” Байгууллага	
“Д” Байгууллага	
“Е” Байгууллага	
“Ж” Байгууллага	
“И” Байгууллага	X
“К” Байгууллага	
“Л” Байгууллага	

Засгийн газрын байгууллагуудын хяналт нь дүрэм эсвэл бүрэн эрх олгох бусад хууль тогтоомжоор үүсдэг. Улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудын (арилжааны байгууллагуудын) хяналт нь дүрмээр үүсдэг бөгөөд “В” ба “Г” байгууллагын хувьд өмчлөлийн хувь оролцоогоор хяналтыг тогтоодог. “Л” байгууллагын өмчийн дийлэнх хэсгийг хувийн хөрөнгө оруулагчдад борлуулсан боловч засгийн газар нь хууль тогтоомжийн бүрэн эрхээр дамжуулан “Л” байгууллагын хяналтыг хадгалж үлдсэн.

<b>Аж ахуйн нэгж</b>	<b>Өмчлөлийн хувь оролцоо (%)</b>	<b>Саналын эрх (%)</b>
“В” байгууллага	XX	XX
“Г” байгууллага	XX	XX
“Л” байгууллага	XX	XX

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

*(“Х” засгийн газрын Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс, үргэлжлэл)*

**Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны нэгжүүдийн худалдан авалт (2.1.57, 2.1.58-р параграф)**

Худалдан авсан байгууллагуудын нэрс	Олж эзэмшсэн өмчлөлийн хэмжээ %	Худалдан авалтын төлбөр (мянган валютын нэгж)	Худалдан авалтын төлбөрөөс мөнгөөр төлсөн дүн (мянган валютын нэгж)	Олж эзэмшсэн мөнгөний үлдэгдэл (мянган валютын нэгж)
“В” байгууллага	XX	X	X	X
“Г” байгууллага	XX	X	X	X
		X	X	X

*Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны нэгжүүдийн данснаас хасалт*

Данснаас хассан байгууллагын нэр	Данснаас хассан өмчлөлийн хэмжээ %	Данснаас хасалтын төлбөр (мянган валютын нэгж)	Данснаас хасалтын төлбөрөөс мөнгөөр авсан дүн (мянган валютын нэгж)	Данснаас хассан мөнгөний үлдэгдэл (мянган валютын нэгж)
“И” байгууллага	XX	X	X	X

**Тэмдэглэл Б: Томоохон хамтын хэлэлцээрүүд (2.1.62-р параграф)**

Хамтын хэлэлцээрийн нэр	Үндсэн үйл ажиллагаа	Үр дүн дэх хувь оролцоо	
		200X %	200X-1 %
Бүсийн Усны Зөвлөл	Усан хангамж	XX	XX
Бүсийн Эрчим Хүчний Зөвлөл	Ашиглалтын үйлчилгээ үзүүлэлт	XX	XX



(“Х” засгийн газрын Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс, үргэлжлэл)

**Тэмдэглэл В: Хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал (2.1.24(а) параграф)**

*Үндсэн хөрөнгө*

Засгийн газар нь өөрийн үндсэн хөрөнгийн гол ангиудыг тодорхойлох ба үнэ цэнийг тогтоох ажиллагааг эхлүүлсэн. Тэдгээр хөрөнгийг түүхэн өртгөөр эсвэл үнэлсэн дүнгээр илэрхийлдэг. Үнэлгээг хараат бус мэргэжлийн үнэлгээчин гүйцэтгэсэн. Хөрөнгийн ангилал тус бүрийн хувьд хэрэглэсэн үнэлгээний суурь нь дараах байдалтай байна:

<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>Өртөг</b>
Газар	Одоогийн үнэ цэнэ
Барилга	Өртөг эсвэл зах зээлийн үнэ цэнэ

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
Машин, тоног төхөөрөмж	X	X
Газар ба барилга		
Улс орны хязгаарын (улс, муж, хот) доторх үл хөдлөх хөрөнгө	X	X
Барилга, өртгөөр	X	X
Барилга, үнэлгээгээр	X	X
	X	X

*Орлого, зардал*

Засгийн газар нь санхүүгийн тайлагналын аккруэл суурьт шилжихийн хэрээр тухайн тайлант үеийн орлого, зардлын талаархи мэдээг үргэлжлүүлэн бүрдүүлдэг.

Татварын албанаас гурван жил тутам үнэлэн тогтоосон үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэд үндэслэн засгийн газар нь төлвөл зохих үл хөдлөх хөрөнгийн татвар болон тухайн тайлангийн өдрөөрх татварын өглөгийн бүртгэлийг хөтөлдөг. Засгийн газар нь борлуулалтын болон үйлдвэрлэлийн тайлан, илтгэлд үндэслэн хуримтлуулан тооцох бараа, үйлчилгээний татвар ба [салбарын нэрийг бичих] эрхийн шимтгэлийн дүнг бас тооцоолдог.

Засгийн газар нь 200X-3 оноос хойш бүрдүүлсэн татварын статистик болон бусад мэдээлэлд, үүн дотроо долоо хоног тутмын дундаж ашиг, дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглэгчийн ба үйлдвэрлэгчийн үнийн индексэд үндэслэн орлогын татварын орлогыг аккруэл сууриар хэмжих статистик загварыг боловсруулж байна. Уг загвар нь 20XX оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үеийн хувьд орлогын татварын орлогыг аккруэл сууриар найдвартай хэмжих боломжийг олгоно гэж Засгийн газар урьдчилан таамаглаж байна.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

(“Х” засгийн газрын Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс, үргэлжлэл)

Хуримтлагдсан зардал нь төлвөл зохих цалин хөлс, түрээс, бусад зардал болон тухайн тайлангийн өдрөөрх тэдгээрийн өглөгийн дүнгээс бүрддэг.

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
<b>Хуримтлагдсан орлого</b>		
Үл хөдлөх хөрөнгийн татвар	X	X
Бараа, үйлчилгээний татвар	X	X
Эрхийн шимтгэл	X	X
	<b>X</b>	<b>X</b>
<b>Хуримтлагдсан зардал</b>		
Цалин хөлс	X	X
Түрээс	X	X
Бусад	X	X
	<b>X</b>	<b>X</b>

**Зээл**

Засгийн газрын зээлийг доор жагсаан харуулав:

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
Жилийн эхний үлдэгдэл	X	X
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>		
Дотоодын арилжааны санхүүгийн байгууллага	X	X
Гадаадын арилжааны санхүүгийн байгууллага	X	X
Хөгжлийн банкууд ба адилтгах зээлдүүлэгч агентлагууд	X	X
<b>Нийт зээл</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>БУЦААН ТӨЛӨЛТ</b>		
Дотоодын арилжааны санхүүгийн байгууллага	(X)	(X)
Гадаадын арилжааны санхүүгийн байгууллага	(X)	(X)
Хөгжлийн банкууд ба адилтгах зээлдүүлэгч агентлагууд	(X)	(X)
<b>Нийт буцаан төлөлт</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
Жилийн эцсийн үлдэгдэл	X	X

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРЬТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

("Х" засгийн газрын Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс, үргэлжлэл)

**Тэмдэглэл Г: Байгууллага нь өөрийн төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй үеийн төсвийн зэрэгцүүлэлт (2.1.24(б) параграф)**

(мянган валютын нэгжээр)	Гүйцэтгэл	Төсөв	Хэлбэлзэл
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>			
<b>Татвар</b>			
Орлогын татвар	X	X	X
Нэмэгдсэн өртгийн албан татвар	X	X	(X)
Үл хөдлөх хөрөнгийн татвар	X	X	X
Бусад татвар	X	X	(X)
	X	X	X
<b>Туслалцаа - Туслалцааны хэлэлцээр</b>			
Олон улсын агентлаг	X	X	-
Бусад буцалтгүй тусламж ба туслалцаа	X	X	-
	X	X	-
<b>Зээл</b>			
Зээлийн мөнгөн орлого	X	X	(X)
<b>Капитал мөнгөн орлого</b>			
Үндсэн хөрөнгийн данснаас хасалтын мөнгөн орлого	X	X	X
<b>Худалдаа арилжааны үйл ажиллагаа</b>			
Худалдаа арилжааны үйл ажиллагааны мөнгөн орлого	X	X	X
<b>Бусад мөнгөн орлого</b>			
	X	X	X
<b>Нийт мөнгөн орлого</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>			
<b>Үйл ажиллагаа</b>			
Цалин, хөлс ба ажиллагчдын тэтгэмж	(X)	(X)	(X)
Хангамжийн болон хэрэглээний зүйлс	(X)	(X)	(X)
	(X)	(X)	(X)
<b>Шилжүүлэг</b>			
Буцалтгүй тусламж	(X)	(X)	-
Бусад шилжүүлгийн төлбөр	(X)	(X)	-
	(X)	(X)	-
<b>Капитал зарлага</b>			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт/барьж байгуулалт	(X)	(X)	(X)
Санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалт	(X)	(X)	-
	(X)	(X)	(X)
<b>Зээл ба хүүний буцаан төлөлт</b>			
Зээлийн буцаан төлөлт	(X)	(X)	-
Хүүний буцаан төлөлт	(X)	(X)	-
	(X)	(X)	-
<b>Бусад төлбөр</b>			
	(X)	(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлага</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
<b>ЦЭВЭР МӨНГӨН ОРЛОГО/(ЗАРЛАГА)</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

("Х" засгийн газрын Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс, үрэлжлэл)

**Тэмдэглэл Г2: Байгууллага нь хоёр жилийн төсөв бэлтгэдэг тохиолдол**

**Мөнгөн суурьт хоёр жилийн төсөв — 200X оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жил (2.1.30-р параграф)**

(мянган валютын нэрж)		Хоёр жи- лийн анх- ны төсөв	1 дэх жи- лийн зас- -тот төсөв	1 дэх жи- лийн зас- вар- ласан төсөв	Зэрэг- цүүлэг дэх суу- риарх 1 дэх жилийн гүйцэт- гэл	2 дахь жилд ашиг- лах боломж -той үлдэг- дэл	2 дахь жи- лийн зорил тот төсөв	2 дахь жи- лийн зас- вар- ласан төсөв	Зэрэг- цүүлэг- дэх суу- риарх 2 дахь жилийн гүйцэт- гэл	Төсвийн хуа- цаан дахь төсөв ба гүйцэт- гэлийн зөрүү*
<b>МӨНГӨН ОРЛОГО</b>										
Татвар		X	X	X	X	X	X	X	X	X
Тусалцааны хэлэлцээр		X	X	X	X	X	X	X	X	X
Зээлийн мөнгөн орлого		X	X	X	X	X	X	X	X	X
Үндсэн хөрөнгө данснаас хасалтын мөнгөн орлого		X	X	X	X	X	X	X	X	X
Санхүүгийн хэрэглүүрийн данснаас хасалтын мөнгөн орлого		X	X	X	X	X	X	X	X	X
Бусад орлого		X	X	X	X	X	X	X	X	X
<b>Нийт мөнгөн орлого</b>		<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>МӨНГӨН ЗАРЛАГА</b>										
Эрүүл мэнд		(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Боловсрол		(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Нийтийн хэв журам, аюулгүй байдал		(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Нийгмийн хамгаалал		(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Батлан хамгаалах		(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Орон сууц, нийтийн аж ахуй		(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Амралт зугаалга, соёл, шашин		(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Эдийн засаг		(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Байгаль орчны хамгаалал		(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Бусад		(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
<b>Нийт мөнгөн зарлага</b>		<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
<b>ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

\* Энэ баганыг оруулах албагүй. Гэвч анхны эсвэл тодотгосон гэдгийг зохих ёсоор тодорхойлсон төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусган оруулж болох юм.

**Тэмдэглэл Д: Гуравдагч талын төлбөр (2.1.77-р параграф)**

“Х” засгийн газар нь тайлант үеийн туршид түүний өмнөөс бараа, үйлчилгээ худалдан авахын тулд гуравдагч талын хийсэн төлбөрөөс үр өгөөж хүртдэг. Эдгээр төлбөр нь засгийн газрын мөнгөн орлого буюу мөнгөн зарлагыг бүрдүүлэхгүй юм. Энэ нь олон талт ба хоёр талт тусламжийн агентлагууд болон төрийн бус байгууллагуудаас төлсөн бараа, үйлчилгээний төлбөрүүдээс бүрддэг. Эдгээр төлбөр нь гадаадын болон бусад тусламж байдлаар засгийн газрын хөтөлбөрийн хувьд үзүүлсэн дэмжлэгийн нэг хэсэг болдог. Гадаадын болон бусад тусламжийн талаархи нэмэлт мэдээллийг доорх Тэмдэглэл Е-д харуулав. 200Х ба 200Х-1 онд бараа, үйлчилгээ худалдан авахын тулд гуравдагч талуудын хийсэн дараах төлбөрүүдийг Засгийн газраас шалгасан.

**ГУРАВДАГЧ ТАЛЫН ТӨЛБӨРҮҮД**

(мянган валютын нэгжээр)	200Х	200Х-1
Цалин, хөлс	X	X
Хангамжийн болон хэрэглээний зүйлс	X	X
Капитал төлбөр	X	X
Зээлийн болон хүүний төлбөр	X	X
<b>Гуравдагч талын төлбөрийн нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>

**Тэмдэглэл Е: Гадаадын болон бусад тусламж (2.1.90, 2.1.91-р параграф)**

Мөнгө хэлбэрээр авсан тусламжийг тухайн засгийн газрын хянадаг харилцах данс, хугацаатай хадгаламж болон итгэлцлийн сангийн дансанд шилжүүлж, байршуулдаг. Энэ нь мөн гадаадын болон бусад тусламжийн хэлцэл, бусад зөвшөөрлийн дагуу доноруудын данснаас тухайн засгийн газрын татан авсан дүнгүүдийг агуулсан байдаг. Тусламжийг гуравдагч талын төлбөр хэлбэрээр бас хүлээн авсан.

Гадаад тусламж нь тухайн тусламжийг ашиглан зарцуулах зориулалтыг тусгайлан заасан хэлцлийн дагуу олон талт ба хоёр талт донор агентлагуудаас хүлээн авсан зээл болон буцалтгүй тусламжаас бүрддэг. Бусад тусламжийг ТББ, хувийн компани болон бусад доноруудаас тусгайлан заасан зорилгоор хүлээн авсан.

Тухайн тайлант үеийн туршид хүлээн авсан гадаад тусламжийн дүн, тусламж үзүүлэгчийн анги болон зорилгыг доор харуулав.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

(“X” засгийн газрын Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс, үргэлжлэл)

**Хүлээн авсан гадаадын болон бусад тусламж (2.1.90(а), (б), (в), (г) параграф ба 2.1.91-р параграф)**

(мянган валютын нэгжээр)	200X	200X-1
<b>Гадаад тусламж</b>		
Мөнгөн орлогын нийт дүн	X	X
Гуравдагч талын төлбөрийн нийт дүн	X	X
<b>Гадаад тусламжийн нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Олон талт тусламжийн агентлагууд</b>		
Мөнгөн орлогын нийт дүн	X	X
Гуравдагч талын төлбөрийн нийт дүн	X	X
Олон талт тусламжийн агентлагуудын нийт дүн	X	X
<b>Хоёр талт тусламжийн агентлагууд</b>		
Мөнгөн орлогын нийт дүн	X	X
Гуравдагч талын төлбөрийн нийт дүн	X	X
Хоёр талт тусламжийн агентлагуудын нийт дүн	X	X
<b>Бусад тусламж</b>		
Мөнгөн орлогын нийт дүн	X	X
Гуравдагч талын төлбөрийн нийт дүн	X	X
<b>Бусад тусламжийн нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Төрийн бус байгууллагууд (ТББ)</b>		
Мөнгөн орлогын нийт дүн	X	X
Гуравдагч талын төлбөрийн нийт дүн	X	X
ТББ-ын нийт дүн	X	X
<b>Хувийн компаниуд ба бусад донорууд</b>		
Мөнгөн орлогын нийт дүн	X	X
Хувийн компаниуд ба бусад доноруудын нийт дүн	X	X

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

(“Х” засгийн газрын Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс, үргэлжлэл)

(мянган валютын нэгжээр)	200X	200X+1
<b>Зээлийн сан</b>		
Гадаад тусламж	X	X
<b>Зээлийн сангийн нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Буцалтгүй тусламж ба хандив</b>		
Гадаад тусламж	X	X
Бусад тусламж	X	X
<b>Буцалтгүй тусламж ба хандивын нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>

**Гадаадын болон бусад тусламжийг үзүүлсэн ба ашигласан зорилго (2.1.90(д) параграф ба 2.1.91-р параграф)**

*Гадаад тусламж*

Тусламжийг дараах зориулалтаар ашиглана гэдгийг тусгайлан заасан хэлэлцээрийн дагуу тайлант үед олон талт болон хоёр талт гадаад тусламжийн агентлагуудаас гадаад тусламжийг хүлээн авсан:

	Хөгжлийн тусламж		Яаралтай тусламж		Бусад		Бүгд	
	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1
<b>Зээлийн сан</b>	X	X	-	-	X	-	X	X
<b>Буцалтгүй тусламжийн сан</b>	X	-	X	X	-	-	X	X
<b>Нийт дүн</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>-</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Ашигласан дүн</b>	X	X	X	X	X	-	X	X

*Бусад тусламж*

Тайлант үеийн туршид бусад тусламжийг төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн компаниуд болон бусад доноруудаас дараах зориулалтаар буцалтгүй тусламж ба хандив байдлаар хүлээн авсан:

	Хөгжлийн тусламж		Яаралтай тусламж		Бусад		Бүгд	
	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1	200X	200X-1
<b>Буцалтгүй тусламж ба хандив</b>	X	X	X	X	X	X	X	X
<b>Ашигласан дүн</b>	X	X	X	X	X	X-	X	X

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

(“Х” засгийн газрын Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлийн хэсгээс, үргэлжлэл)

**Зарцуулаагүй гадаадын болон бусад тусламж (2.1.90(е) ба 2.1.91-р параграф)**

Зарцуулаагүй гадаад тусламжийн зээл, буцалтгүй тусламж нь гадаад тусламжийн агентлагуудтай байгуулсан заавал биелүүлэх хэлцэлд тусгайлан заасан дүнгүүдээс бүрддэг боловч тайлангийн өдрөөр ашиглаагүй байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд биелүүлсэн болон ирээдүйд ханган биелүүлэхээр урьдчилан таамаглаж буй нөхцөл, болзолд захирагддаг. 200Х буюу 200Х-1 онд ТББ-ууд болон бусад тусламж үзүүлэгчдээс хүлээн авсан боловч зарцуулаагүй дүн байхгүй.

	Хөгжлийн тусламж		Яаралтай тусламж		Бусад		Бүгд	
	200Х	200Х-1	200Х	200Х-1	200Х	200Х-1	200Х	200Х-1
Эцсийн үлдэгдэл-Зээл	X	X	-	-	X	X	X	X
Эцсийн үлдэгдэл-Буцалтгүй тусламж	X	X	-	-	X	X	X	X

**Хүлээн авсан бараа, үйлчилгээ (2.1.100-р параграф)**

200Х онд ZZZ бүсэд маш хүчтэй газар хөтлөлт болж, засгийн газрын өмч хөрөнгө болон хувийн өмч хөрөнгөд, түүнчлэн ард иргэдэд асар их хохирол учруулсан. Хэд хэдэн улсын олон талт ба хоёр талт тусламжийн агентлаг, ТББ-ууд, хувийн компаниуд, эвсэл холбоод нь бул чулуунд дарагдсан хүмүүсийг аврах, шилжүүлэн байршуулахад туслахын тулд хүн хүчний болон тонон төхөөрөмжийн хандив туслалцаа үзүүлсэн. Түүнчлэн, сэтгэл заслаар сурч дадлагажсан мэргэшсэн эмнэлгийн ажилтнуудын багийг эмнэлгийн тоног төхөөрөмжийн хамт тус бүсэд илгээсэн. Мөн түр хоргодох байр, хувцас, хоол хүнсээр хангасан. Хүлээн авсан бараа, үйлчилгээний үнэ цэнийг ХХ дотоодын валютын нэгж болсон гэж тооцоолсон. Яаралтай тусламжийн хувьд адилтгах бараа, үйлчилгээний дотоод үнэ бэлэн боломжтой байхгүй учраас гол хандивлагчид болох олон улсын тусламжийн агентлагууд, ТББ-ууд, компаниудын гаргасан өртгийн тооцоололд үндэслэн тэдгээрийн үнэ цэнийг тодорхойлсон.

Тайлант жилд тавин мянган тонн цагаан будааг хүнсний туслалцаа байдлаар хүлээн авсан. Дотоодын бөөний зах зээл дэх адилтгах будааны бөөний үнийг харгалзан үүнийг ХХ дотоод валютын нэгж гэж үнэлсэн.

Тухайн жилийн туршид хүлээн авсан бараа, үйлчилгээг Мөнгөн орлого, зарлагын тайланд тайлагнаагүй бөгөөд Засгийн газрын (шууд буюу шууд бусаар) хүлээн авсан эсвэл төлсөн мөнгийг зөвхөн тусгасан. Мөнгөн бус бараа, үйлчилгээг яаралтай тусламжийн нэг хэсэг байдлаар хүлээн авсан бөгөөд энэхүү тэмдэглэлд тусгасан.



## Хавсралт 3

### **УСНББОУС 2, Мөнгөн Гүйлгээний Тайлан-гаар шаардсан загвараар бэлтгэсэн Мөнгөн орлого, зарлагын тайлангийн толилуулга**

*Санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон аккруэл УСНББОУС-ын мөрдөлтөнд шилжиж буй байгууллага нь мөнгөн орлого, зарлагын тайлангаа УСНББОУС 2, “Мөнгөн Гүйлгээний Тайлан”-гаар шаардсантай ижил загвараар толилуулахыг энэ Стандартын Хоёрдугаар хэсгийн 2.2.1-р параграфтаар сайшаан дэмжсэн. Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар тайлагнаж буй байгууллага нь УСНББОУС 2-ыг мөрдөнө.*

*УСНББОУС 2-ын гол төлөв хандлагуудын тойм болон энэ Стандартаар шаардсан нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуух санхүүгийн тайлагналд түүнийг мөрдөх талаархи заавар удирдамжийг энэхүү Хавсралтад тусгасан. Мөнгөн орлого, зарлагын тайлангаа тохиромжтой тохиолдолд УСНББОУС 2-ын шаардлагуудын дагуу толилуулах санаа зорилго бүхий байгууллагууд нь уг УСНББОУС-ыг лавлагаа болгон харгалзах шаардлагатай.*

### **УСНББОУС 2, “Мөнгөн Гүйлгээний Тайлан”-гаар шаардсан загвараар толилуулах**

1. Санхүүгийн тайлагналын аккруэл суурь болон **аккруэл УСНББОУС-ын мөрдөлтийн** дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь тайлант үеийн мөнгөн гүйлгээг доор тодорхойлсончлон, үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны гэж ангилан тайлагнах мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэхийг УСНББОУС 2-оор шаарддаг.

#### **Тодорхойлолтууд**

2. Санхүүгийн үйл ажиллагаа нь байгууллагын хувь нийлүүлсэн капитал ба зээлийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах үр дүн бүхий үйл ажиллагаа юм.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь мөнгөтэй адилтгах хөрөнгөнд хамаарахгүй урт хугацаат хөрөнгө ба бусад хөрөнгө оруулалтыг худалдан авах болон данснаас хасах үйл ажиллагаа юм.

Үндсэн үйл ажиллагаа нь байгууллагын хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа юм.

#### **Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд**

3. Мөнгөн орлого, зарлагын тайлангаа энэхүү загвараар толилуулахдаа, нэг ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн гүйлгээг өөр өөр арга замаар ангилах шаардлагатай байж болно (УСНББОУС 2-оор шаардсантай ижил

загвараар толилуулах мөнгөн орлого, зарлагын тайлангийн хувьд энэ Хавсралтын үлдсэн хэсэгт “мөнгөн гүйлгээний тайлан” гэсэн нэр томъёог ашигласан). Жишээлбэл; зээлийг буцаан төлөх мөнгө нь хүү ба үндсэн төлбөрийн аль алиныг агуулах тохиолдолд төлбөрийн хүүний хэсгийг үндсэн үйл ажиллагааны, зээлийн үндсэн төлбөрийг санхүүгийн үйл ажиллагааны гэж ангилж болох юм. Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх замаар өөрийн мэдээллийг толилуулж буй байгууллага нь үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээг өөрийн үйл ажиллагаанд хамгийн тохиромжтой арга маягаар толилуулна.

4. Мөнгөн гүйлгээний тайлан нь дараах дүнгүүдийг толилуулах мөрийн зүйлсийг агуулсан байна:

- (а) Үндсэн үйл ажиллагааны нийт мөнгөн орлого;
- (б) Үндсэн үйл ажиллагааны нийт мөнгөн зарлага;
- (в) Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ;
- (г) Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ;
- (д) Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ;
- (е) Мөнгөний эхний ба эцсийн үлдэгдэл; ба
- (ж) Мөнгөний цэвэр өсөлт эсвэл бууралт.

Нэмэлт мөрийн зүйлс, гарчиг, дэд дүнгүүдийн толилуулга нь тухайн байгууллагын мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулахад шаардлагатай тохиолдолд тэдгээрийг мөнгөн гүйлгээний тайланд бас толилуулна.

5. Байгууллага нь мөнгөн гүйлгээний тайланд эсвэл тэмдэглэлд дараах зүйлсийг мөн толилуулна:

- (а) Цэвэр дүнгээр тайлагнахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.13-р параграфтаар зөвшөөрснөөс бусад тохиолдолд үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн нийт мөнгөн орлого ба нийт мөнгөн зарлагын гол ангиуд;
- (б) Тухайн байгууллагын үйл ажиллагаанд тохиромжтой арга маягаар харуулсан үндсэн үйл ажиллагааны нийт мөнгөн орлогын дэд ангилал; ба
- (в) Зарлагын шинж төрөл эсвэл тухайн байгууллагын хүрээн дэх чиг үүргийн аль тохиромжтойд үндэслэсэн ангилал ашиглан хийсэн үндсэн үйл ажиллагааны зарлагын задаргаа шинжилгээ.

Капитал худалдан авалт болон хүү, ногдол ашгийн хувьд хийсэн төлбөрийн тусдаа тодруулга нь УСНББОУС 2-ын шаардлагуудтай мөн нийцсэн байна.

6. Мөнгийг татвар, хураамж, торгууль (үндсэн үйл ажиллагаа), капитал хөрөнгийн борлуулалт (хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа) ба/буюу

зээлээс (санхүүгийн үйл ажиллагаа) үүсгэн бий болгосон эсэх, түүнийг үйл ажиллагааны зардал, капитал хөрөнгийн худалдан авалт (хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа) эсвэл өр барагдуулалтад (санхүүгийн үйл ажиллагаа) зарцуулсан эсэх гэх мэт асуудлуудын талаархи мэдээллийн тодруулга нь санхүүгийн тайлангийн ил тод ба хариуцлагатай байдлыг сайжруулдаг. Эдгээр тодруулга нь мөн тухайн байгууллагын одоогийн мөнгөний нөөц, ирээдүйн мөнгөн орлогын магадлалт эх үүсвэр болон тогтвортой байдлын талаар илүү их мэдээлэл бүхий шинжилгээ, үнэлгээнд туслалцаа үзүүлдэг. Иймээс бүх байгууллагууд нь энэхүү мэдээллийг санхүүгийн тайлан ба/буюу холбогдох тэмдэглэлд тодруулахыг энэхүү Стандартаар сайшаан дэмждэг.

### Үндсэн үйл ажиллагаа

7. Үндсэн үйл ажиллагаанаас үүсэх цэвэр мөнгөн гүйлгээний дүн нь тухайн байгууллагын үйл ажиллагааг дараах байдлаар санхүүжүүлсэн хэмжээг илэрхийлэх гол үзүүлэлт юм:

- (а) (Шууд ба шууд бус) татвараар; эсвэл
- (б) Тухайн байгууллагын нийлүүлсэн бараа, үйлчилгээг хүлээн авагчдаар.

Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүнгийн тодруулга нь зээлийг буцаан төлөх, өөрийн эздэд ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг төлөх, санхүүжилтийн гадаад эх үүсвэрээс мөнгө авахгүйгээр шинэ хөрөнгө оруулалтуудыг хийхэд ашиглах мөнгө бий болгох тухайн байгууллагын үйл ажиллагааны хүчин чадлыг тодорхойлоход мөн туслалцаа үзүүлдэг. Нийт засгийн газрын түвшний нэгтгэсэн, үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь өөрийн одоогийн үйл ажиллагааг уг Засгийн газар татвар болон төлбөрөөр санхүүжүүлсэн хэмжээг илэрхийлэх үзүүлэлтээр хангадаг. Үндсэн үйл ажиллагааны урьд өмнөх түүхэн мөнгөн гүйлгээний тодорхой бүрдэл хэсгүүдийн талаархи мэдээлэл нь бусад мэдээллийн хамтаар уг үндсэн үйл ажиллагааны ирээдүйн мөнгөн гүйлгээг прогнозчилоход ач холбогдолтой байдаг.

8. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагын мөнгө бий болгох үндсэн үйл ажиллагаанаас юуны өмнө үүсдэг. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний жишээг доор дурдав:

- (а) Татвар, хураамж, торгуулиас бий болсон мөнгөн орлого;
- (б) Тухайн байгууллагын нийлүүлсэн бараа, үйлчилгээний төлбөрөөс орсон мөнгөн орлого;
- (в) Буцалтгүй тусламж буюу шилжүүлэг ба төв засгийн газар эсвэл улсын секторын бусад байгууллагуудаас олгосон, үүн дотроо капитал хөрөнгийн худалдан авалтын хувьд олгосон бусад хуваарилалт болон төсвийн бусад эрх мэдлээс үүссэн мөнгөн орлого;
- (г) Эрхийн шимтгэл, төлбөр, хураамж ба бусад орлогоос бий болсон мөнгөн орлого;

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- (д) Улсын секторын бусад байгууллагуудад тэдгээрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан олгосон мөнгөн төлбөр (үүнд: зээл болон өмчийн санхүүжилт хамаарахгүй);
  - (е) Бараа, үйлчилгээний хувьд бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгөн төлбөр;
  - (ж) Ажиллагчдад төлсөн эсвэл тэдний өмнөөс төлсөн мөнгөн төлбөр;
  - (и) Улсын секторын даатгалын байгууллагын даатгалын хураамж, хохирлын төлбөр, аннуити болон даатгалын гэрээний бусад үр өгөөжийн мөнгөн орлого ба мөнгөн төлбөр;
  - (к) Үндсэн үйл ажиллагаанд хамаарах үл хөдлөх хөрөнгийн орон нутгийн татвар эсвэл орлогын албан татварын (хамааралтай бол) мөнгөн төлбөр;
  - (л) Худалдаа буюу арилжааны зорилготой гэрээнээс үүссэн мөнгөн орлого ба мөнгөн төлбөр;
  - (м) Зогсоосон үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн орлого буюу мөнгөн төлбөр; ба
  - (н) Зарга, маргааны барагдуулалттай холбоотой мөнгөн орлого буюу мөнгөн төлбөр;
9. Байгууллага нь үнэт цаас болон зээлийг арилжаа буюу худалдааны зорилгоор эзэмшиж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээр нь буцаан борлуулах зорилгоор тусгайлан худалдан авсан бараа материалтай ижил байдаг. Иймээс арилжаа буюу худалдааны зорилготой үнэт цааснуудын худалдан авалт, борлуулалтаас үүссэн мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилдаг. Үүнтэй адилаар, улсын санхүүгийн байгууллагаас олгосон мөнгөн урьдчилгаа ба зээл нь тухайн байгууллагын мөнгө бий болгох гол үйл ажиллагаатай холбоотой учраас тэдгээрийг ихэвчлэн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилдаг.
10. Зарим улс оронд, засгийн газар буюу улсын секторын бусад байгууллагууд нь тухайн байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд төсөв хуваарилах буюу мөнгө сангийн эрх олгодог боловч тэдгээр мөнгө санг урсгал үйл ажиллагаанд, капитал ажилд болон хувь нийлүүлсэн капиталд хуваарилан зарцуулах талаар тодорхой ялган заагаагүй байдаг. Байгууллага нь төсвийн хуваарилалт буюу төсвийн эрхийг урсгал үйл ажиллагаа, капитал ажил (үндсэн үйл ажиллагаа), хувь нийлүүлсэн капитал (хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа) гэдгээр тус тусад нь ялган тодорхойлох боломжгүй тохиолдолд уг төсвийн хуваарилалт буюу төсвийн эрхийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байдлаар ангилах бөгөөд санхүүгийн тайлангийн тэмдэглэлд энэ тухай тодруулга хийх хэрэгтэй гэж УСНББОУС 2-т тайлбарласан байдаг.

### **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа**

11. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээний тусдаа тодруулга нь тухайн байгууллагын ирээдүйн үйлчилгээ үзүүлэлтэнд хувь

нэмрээ оруулах зориулалт бүхий нөөцийн хувьд зарцуулсан мөнгөн зарлагын гүйлгээний дүнг илэрхийлдэг. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээний жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгийг худалдан авахад төлсөн мөнгө. Капиталжуулсан хөгжүүлэлтийн зардал болон өөрөө барьж байгуулсан үндсэн хөрөнгөтэй холбоотой төлбөрүүд нь энэхүү дүнд хамаарна;
- (б) Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгийг борлуулсны мөнгөн орлого;
- (в) Бусад байгууллагуудын өмчийн буюу өрийн хэрэглүүр болон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог худалдан авахад төлсөн мөнгөн төлбөр (мөнгөтэй адилтгах хөрөнгө гэж үзэх хэрэглүүр эсвэл худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж буй хэрэглүүрийн хувьд төлснөөс бусад мөнгөн төлбөр);
- (г) Бусад байгууллагуудын өмчийн буюу өрийн хэрэглүүр болон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны борлуулалтаас үүссэн мөнгөн орлого (мөнгөтэй адилтгах хөрөнгө гэж үзэх хэрэглүүр болон худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж буй хэрэглүүрээс үүссэнээс бусад мөнгөн орлого);
- (д) Бусад талуудад олгосон зээл ба мөнгөн урьдчилгаа (улсын санхүүгийн байгууллагаас олгосон зээл ба мөнгөн урьдчилгаанаас бусад);
- (е) Бусад талуудад олгосон зээл ба мөнгөн урьдчилгааны буцаан төлөлтөөс хүлээн авсан мөнгө орлого (улсын санхүүгийн байгууллагын зээл ба мөнгөн урьдчилгаанаас бусад);
- (ж) Худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж байгаа гэрээ эсвэл мөнгөн төлбөрүүдийг нь санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилснаас бусад тохиолдолд фьючерс гэрээ, форвард гэрээ, опционы гэрээ, свопын гэрээний хувьд төлсөн мөнгө төлбөр; ба
- (и) Худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж байгаа гэрээ эсвэл мөнгөн орлогуудыг нь санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилснаас бусад тохиолдолд фьючерс гэрээ, форвард гэрээ, опционы гэрээ, свопын гэрээнээс үүссэн мөнгө орлого.

Гэрээг тодорхойлж болох төлөв байдлын хейж гэж тайлагнасан тохиолдолд уг гэрээний мөнгөн гүйлгээг тухайн хейж хийж буй төлөв байдлын мөнгөн гүйлгээтэй ижил арга замаар ангилна.

### **Санхүүгийн үйл ажиллагаа**

12. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тусдаа тодруулга нь тухайн байгууллагад капитал нийлүүлэгчдийн зүгээс ирээдүйн мөнгөн гүйлгээнд тавих шаардлагыг урьдчилан таамаглахад ач холбогдолтой байдаг. Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээний жишээнд дараах зүйлс хамаарна:

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- (а) Баталгаагүй өрийн бичиг, зээл, баталгаат өрийн бичиг, бонд, моргейжийн (үл хөдлөх хөрөнгийн барьцаат) болон бусад богино буюу урт хугацаат зээллэгийн хэрэглүүр гаргалтаас хүлээн авсан мөнгөн орлого;
- (б) Зээлийг буцаан төлөх мөнгөн төлбөр;
- (в) Санхүүгийн түрээстэй холбоотой төлөгдөөгүй өр төлбөрийн бууралт болгон түрээслэгчийн төлсөн мөнгөн төлбөр.
- (г) Валютын гаргалт эсвэл эргэлтээс гаргалттай холбоотой мөнгөн орлого, зарлага.

### **Хүү ба ногдол ашиг**

- 13. Хүлээн авсан ба төлсөн хүү, ногдол ашгаас үүссэн мөнгөн гүйлгээний тусдаа тодруулга хийхийг УСНББОУС 2-оор шаардсан байдаг. Ийм тодруулга хийдэг тохиолдолд тэдгээр мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны гэдгээр нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай ангилах хэрэгтэй гэж УСНББОУС 2-д бас заасан.
- 14. Тайлант үеийн туршид төлсөн ба хүлээн авсан хүү, ногдол ашгийн нийт дүнг мөнгөн гүйлгээний тайланд толилуулна. Төлсөн хүү ба хүлээн авсан хүү, ногдол ашгийг улсын санхүүгийн байгууллагын хувьд ихэвчлэн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилдаг. Харин бусад байгууллагуудын хувьд төлсөн ба хүлээн авсан хүү, ногдол ашигтай холбоотой мөнгөн гүйлгээг хэрхэн ангилах талаар зөвшилцөлд хүрээгүй байна. Төлсөн хүү ба ногдол ашиг, хүлээн авсан хүү ба ногдол ашгийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилж болох юм. Гэвч нөгөө талаас, төлсөн хүү ба ногдол ашиг, хүлээн авсан хүү ба ногдол ашиг нь санхүүгийн эх үүсвэр олж авах өртөг зардал буюу хөрөнгө оруулалтын өгөөж тул тэдгэрийг харгалзан санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилж болох юм.

### **Орлого, зарлагын гол ангиудын тайлагнал**

- 15. Орлогын дэд ангилал нь тухайн хамаарах дүнгийн хэмжээ, шинж төрөл, чиг үүргээс хамаардаг. Байгууллагын онцлогоос хамааран дараах дэд ангиллууд тохиромжтой байж болно:
  - (а) Татварын орлого (татварын төрлүүдээр цаашид дэд ангилж болно);
  - (б) Хураамж, торгууль, алданги болон зөвшөөрлийн орлого;
  - (в) Арилжааны ажил гүйлгээний орлого, үүн дотроо бараа, үйлчилгээний борлуулалт ба хэрэглэгчдийн төлбөр (эдгээрийг арилжааны ажил гүйлгээ гэж ангилдаг тохиолдолд);
  - (г) Буцалтгүй тусламж, шилжүүлэг буюу төсвийн хуваарилалтын орлого (эх үүсвэрээр ангилж болно); ба

(д) Хүү болон ногдол ашгийн орлого.

16. Тухайн тайлагнагч байгууллагын тодорхой хөтөлбөр, үйл ажиллагаа буюу бусад холбогдох сегментүүдийн өртөг зардал болон өртгийн нөхөлтийг онцлон илэрхийлэхийн тулд зарлагын зүйлсийг дэд ангиллаар харуулдаг. Зарлагын шинж төрөл ба чиг үүргээр хийсэн ангиллын жишээг энэ Стандартын Нэгдүгээр болон Хоёрдугаар хэсэгт тусган харуулсан.

## Хавсралт 4

### Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн чанарын шинжүүд

*Санхүүгийн тайлан нь нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн чанарын шинжүүдийг хангасан ба уг мэдээллийн хязгаарлалтуудыг биелүүлсэн тийм мэдээлэл толилуулахыг энэ Стандартын Нэгдүгээр хэсгийн 1.3.27-р параграфаар шаардсан байдаг. 1.3.27-р параграфт заасан, нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн чанарын шинжүүд ба хязгаарлалтуудыг энэ Хавсралтад хураангуйлан харуулав. Чанарын шинжүүд ба хязгаарлалтуудын талаархи бүрэн тайлбарыг уншигчид нь “Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал”-аас үзэж, танилцах хэрэгтэй.*

Чанарын шинжүүд нь санхүүгийн тайлангаар хангах мэдээллийг хэрэглэгчдэд ач холбогдолтой болгодог бөгөөд санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлдэг шинжүүд юм. Санхүүгийн тайлагналын зорилтууд нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой мэдээллээр хангах явдал юм. Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн сууриас үл хамааран чанарын шинжүүдийг санхүүгийн тайланд хэрэглэдэг. Чанарын шинжүүд нь ойлгомжтой байх, хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх гэсэн шинжүүд юм. Санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн нийтлэг хязгаарлалтууд нь материаллаг байдал, өртөг-өгөөж бөгөөд чанарын шинжүүдийн хоорондох зохих тэнцвэрт хүрэх явдал байдаг.

#### **Ойлгомжтой байх**

Ойлгомжтой байдал нь түүний утгыг ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгодог мэдээллийн чанар юм. Улсын секторын байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлан (санхүүгийн тайлан) нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага ба мэдлэгийн суурь, түүнчлэн толилуулах мэдээллийн шинж төрөлд тохирсон арга замаар мэдээллийг толилуулвал зохино. Байгууллагын үйл ажиллагаа болон түүний үйл ажиллагаа явуулдаг орчны талаар хэрэглэгч нар зохих мэдлэгтэй бөгөөд тухайн мэдээллийг хэрэглэгчид нь уншин судлахад бэлэн байдаг гэж үздэг.

Зарим хэрэглэгчдийн хувьд туслалцаа авахгүйгээр ойлгоход хэт төвөгтэй байж болно гэсэн ганц үндэслэлээр нарийн цогц асуудлуудын талаархи мэдээллийг тухайн санхүүгийн тайланд тусгахгүй орхигдуулж болохгүй юм.

#### **Хамааралтай байх**

Мэдээлэл нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд ялгаатай байдал үүсгэх чадвар боломжтой бол хамааралтай гэж үзнэ. Мэдээлэл нь баталгаажуулах үнэ цэнэтэй, урьдчилан таамаглаж болох үнэ цэнэтэй эсвэл уг үнэ цэнийн аль алиныг агуулсан тохиолдолд ялгаатай байдал үүсгэх боломжтой юм. Хэдийгээр зарим хэрэглэгчид нь ийм мэдээллийн давуу талыг ашиглахгүй байх сонголт



хийсэн буюу түүнийг угаасаа мэддэг байж болох боловч энэ нь ялгаатай байдал үүсгэх, ингэснээр хамааралтай байх боломжтой юм.

### **Үнэн зөв илэрхийлэх**

Санхүүгийн тайлагналын хувьд ач холбогдолтой байхын тулд мэдээлэл нь өөрийн илэрхийлэхийг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн үнэн зөв илэрхийлэл байх ёстой. Тухайн юмс үзэгдлийн илэрхийлэлт нь иж бүрэн, төв голч, материаллаг алдаагүй байх тохиолдолд үнэн зөв илэрхийлэлд хүрдэг. Эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлдэг мэдээлэл нь суурь ажил гүйлгээ, бусад үйл явдал, үйл ажиллагаа буюу нөхцөл байдлын мөн чанарыг дүрслэн харуулдаг. Мөн чанар нь өөрийн хуулийн хэлбэртэй ямагт ижил байх албагүй юм.

### **Зэрэгцүүлэгдэх боломжтой байх**

Хэрэглэгч нар нь хоёр цогц юмс үзэгдлийн хоорондох ижил төсөөтэй болон ялгаатай талуудыг тодорхойлох боломжтой тохиолдолд санхүүгийн тайлан дахь мэдээлэл нь зэрэгцүүлэгдэх боломжтой байдаг. Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь бие даасан мэдээллийн зүйлийн шинж чанар бус, харин мэдээллийн хоёр буюу хэд хэдэн зүйлсийн хоорондох харилцааны шинж чанар юм.

Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь дараах зүйлсэд хамаарна:

- Өөр өөр байгууллагуудын санхүүгийн тайлангуудын зэрэгцүүлэлт; ба
- Нэг байгууллагын өөр өөр тайлант үеүдийн санхүүгийн тайлангуудын зэрэгцүүлэлт.

Зэрэгцүүлэгдэх боломжтой байх шинж чанарын гол утга санаа нь тухайн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан бодлогууд, тэдгээрийн өөрчлөлт, уг өөрчлөлтийн үр нөлөөний талаар хэрэглэгчдэд мэдээлэх явдал юм.

Хэрэглэгчид нь тухайн байгууллагын үр дүнг цаг хугацааны явцад зэрэгцүүлэхийг хүсдэг учраас өмнөх тайлант үеүдийн харгалзах мэдээллийг тухайн санхүүгийн тайланд харуулах нь ач холбогдолтой байдаг.

### **Цаг хугацаандаа байх**

Цаг хугацаандаа байх гэдэг нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой байх өөрийн чадвараа алдахаас өмнө мэдээллийг хэрэглэгчдэд бэлэн байлгахыг хэлнэ. Хамааралтай мэдээллийг нэн даруй бэлэн байлгах нь хариуцлагатай байдал, түүнчлэн гаргах шаардлагатай шийдвэрийг мэдээлэх ба шийдвэрт нөлөөлөх түүний чадварын үнэлгээний хувьд орц болох уг мэдээллийн ач холбогдолтой байдлыг нэмэгдүүлдэг. Цаг хугацаандаа бэлэн байхгүй нь мэдээллийг ач холбогдол багатай болгодог.

### **Шалгах боломжтой байх**

Шалгах боломжтой байдал нь өөрийн илэрхийлэн харуулахыг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг тухайн санхүүгийн тайлан дахь мэдээлэл үнэн

## НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН МӨНГӨН СУУРТ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

зөв илэрхийлсэн гэдгийг хэрэглэгчдэд батлан харуулахад тусалдаг мэдээллийн шинж чанар юм. Санхүүгийн тайланд тодруулсан тайлбар мэдээлэл, түүнчлэн хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус тоон шинжтэй мэдээллийн хувьд хэрэглэх үед энэхүү шинжийг илэрхийлэхийн тулд дэмжигдэх боломжтой байдал гэсэн хэллэгийг зарим тохиолдолд ашигладаг. Шалгах боломжтой байдал эсвэл дэмжигдэх боломжтой байдал гэж нэрлэсэн эсэхээс үл хамааран энэхүү шинж чанар нь зохих мэдлэгтэй, хараат бус өөр өөр ажиглагч нар тухайн илэрхийлэл үнэн зөв эсэх талаар бүрэн тохиролцоонд заавал хүрэх албагүй боловч дараах аль нэг байдлаар ерөнхий зөвшилцөлд хүрч чадна гэсэн утгатай байдаг:

- Тухайн мэдээлэл нь өөрийн илэрхийлэн харуулахыг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг материаллаг алдаагүй буюу гажуудуулан гуйвуулахгүй илэрхийлэх;
- Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт буюу илэрхийллийн тохиромжтой аргыг материаллаг алдаагүй буюу гажуудуулан гуйвуулахгүй мөрдөх.

### **Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн хязгаарлалтууд**

#### *Материаллаг байдал*

Мэдээллийн орхигдуулалт буюу буруу илэрхийлэлт нь тухайн тайлант үеийн хувьд бэлтгэсэн уг байгууллагын санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн шийдвэр эсвэл байгууллагын үүрэг хариуцлагын биелэлтэнд нөлөө үзүүлж чадахаар байвал түүнийг материаллаг гэж үзнэ. Материаллаг байдал нь байгууллага тус бүрийн тухайн нөхцөл байдлын хүрээнд шүүн тунгаасан зүйлийн шинж төрөл ба хэмжээнээс хамаардаг.

#### *Өгөөж ба өртгийн хоорондох тэнцвэр*

Өгөөж ба өртгийн хоорондох тэнцвэр нь нийтлэг хязгаарлалт юм. Мэдээллээс хүртэх өгөөж нь түүнийг бэлтгэх өртгөөс илүү байвал зохино. Санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн бүх өртөг зардал болон бүх үр өгөөжийг тодорхойлох ба/буюу тоогоор илэрхийлэх ихэвчлэн боломжгүй байдаг учраас мэдээллээр хангасны үр өгөөж нь холбогдох өртөг зардлыг зөвтгөн батлах эсэхийг үнэлэх нь ямагт шүүн тунгаалтын асуудал болдог.

Мэдээллээр хангах өртөг зардал нь мэдээллийг олж цуглуулах ба боловсруулах зардал, мэдээллийг шалгах ба/буюу түүнийг дэмжих таамаглалууд болон арга зүйг танилцуулах зардал, мэдээллийг түгээн дамжуулах зардлаас бүрддэг. Хэрэглэгчид нь шинжлэх ба тайлбарлахад зардал гаргадаг.

Тайлан бэлтгэгчид нь санхүүгийн тайланд мэдээлийг тусгахад ихэнх хүчин чармайлтаа гаргадаг. Гэвч үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчид нь эдгээр хүчин чармайлтын өртөг зардлыг эцсийн дүндээ хариуцдаг – яагаад гэвэл үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь санхүүгийн тайланд тусган оруулах мэдээллийг бэлтгэхэд нөөцийг дахин чиглүүлэн хуваарилдаг. Хэрэглэгчид нь санхүүгийн тайлангаар хангах мэдээллийн ихэнх үр өгөөжийг хүртдэг. Гэвч

санхүүгийн тайланд зориулж бэлтгэсэн мэдээллийг удирдлага нь мөн дотооддоо ашиглаж болох бөгөөд удирдлагын илүү сайн шийдвэр гаргалтанд хүргэдэг.

УСНББОУС-ыг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь тухайн санал болгож буй шаардлагуудын үр өгөөж ба өртөг зардлын хүлээгдэж буй шинж төрөл, тоо хэмжээний талаар тайлан бэлтгэгчид, хэрэглэгчид, эрдэмтэн судлаачид болон бусад талуудаас хүлээн авсан мэдээллийг харгалзан үздэг. Тэдгээр тодруулга болон бусад шаардлагуудыг даган мөрдсөний үр өгөөж нь холбогдох өртөг зардлыг зөвтгөн батлана гэж УСНББОУСЗ-өөс үнэлсэн тохиолдолд хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллийг толилуулахад хүргэх бөгөөд чанарын шинжүүдийг хангах тийм тодруулга ба бусад шаардлагуудыг УСНББОУС-д тодорхойлдог.

#### *Чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр*

Чанарын шинжүүд нь мэдээллийн ач холбогдолтой байдалд хувь нэмрээ оруулахын тулд хамтран ажилладаг. Зарим тохиолдолд чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр буюу уялдаа нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахад зайлшгүй шаардлагатай байж болох юм. Нөхцөл байдал тус бүр дэх чанарын шинжүүдийн харьцангуй ач холбогдол нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал юм. Зорилго нь тухайн санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахын тулд чанарын шинжүүдийн хоорондох зохистой тэнцвэрт хүрэх явдал юм.

## **САНАЛ БОЛГОСОН ПРАКТИК УДИРДАМЖ**

Санал болгосон практик удирдамжууд (СБПУ-ууд)-ыг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ) боловсруулж, батлан гаргасан.

УСНББОУСЗ-ийн зорилго нь улсын секторын нягтлан бодох бүртгэлийн өндөр чанартай стандартуудыг тогтоох, тэдгээрийн мөрдөлт ба хэрэгжүүлэлтэнд туслалцаа үзүүлэх, ингэснээр дэлхий дахины практикын чанар ба тууштай байдлыг сайжруулах, улсын секторын санхүүгийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар олон нийтийн эрх ашигт үйлчлэх явдал юм.

Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагууд, үүн дотроо үндэсний, бүсийн, орон нутгийн засгийн газрууд болон засгийн газрын холбогдох агентлагууд ашиглахад зориулсан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (УСНББОУС-ууд) ба СБПУ-уудыг гаргадаг.

УСНББОУС-ууд нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (санхүүгийн тайлан)-д хамааралтай бөгөөд бүрэн эрхтэй байдаг. СБПУ-ууд нь зөвхөн санхүүгийн тайланг биш, харин нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (НЗСТ)-г бэлтгэх сайн практикын талаархи заавар удирдамжаар хангадаг тунхаглалууд юм. УСНББОУС-аас ялгаатай нь, СБПУ нь шаардлагуудыг тогтоодоггүй. Санхүүгийн тайлан биш, харин НЗСТ-тай холбоотой бүх тунхаглалууд нь одоогоор СБУ-ууд байна. СБПУ-ууд нь мэдээлэлд хамаарах баталгааны (хэрэв байгаа бол) түвшний талаархи заавар удирдамжаар хангадаггүй.

## **СБПУ 1—БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ**

### **СБПУ-ийн түүх**

СБПУ 1, *Байгууллагын Санхүүгийн Урт Хугацааны Тогтвортой Байдлын Тайлагнал*-ыг 2013 оны 7-р сард гаргасан.

Үүнээс хойш, СБПУ 1-д дараах УСНББОУС-уудаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал* (2016 оны 4 дүгээр сард гаргасан)

### **СБПУ 1-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт**

<b>Өөрчлөгдсөн параграф</b>	<b>Хэрхэн өөрчилсөн</b>	<b>Юугаар өөрчилсөн</b>
5	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар

## БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

### АГУУЛГА

	Параграф
Зорилт	1
Төлөв байдал ба цар хүрээ	2-8
Тодорхойлолт	9
Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнах эсэхийг тодорхойлох	10-13
Тайлагналын хил хязгаар	14-15
Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнах	16-20
Ирээдүйн орлогын болон зарлагын гүйлгээний төсөөллийг толилуулах	21-26
Хугацааны хамрах хүрээ	25-26
Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүнүүдийг авч үзэх	27-40
Үйлчилгээний хэмжигдэхүүн	31-34
Орлогын хэмжигдэхүүн	35-37
Өрийн хэмжигдэхүүн	38-40
Зарчим ба арга зүй	41-53
Төсөөлөл ба тайлагналын давтамжийг шинэчлэн баяжуулах	41
Хуулийн шаардлагууд ба бодлогын хүрээний үр нөлөө	42
Одоогийн бодлого, хүн ам зүйн болон эдийн засгийн таамаглалууд	43-51
Одоогийн бодлогын таамаглалууд	43-49
Хүн ам зүйн болон эдийн засгийн таамаглалууд	50
Таамаглалын ул үндэслэлтэй байдал	51
Инфляци ба дискаунтын хувь	52
Мэдрэмжийн шинжилгээ	53
Тодруулга	54-58
Хавсралт А: УСНББОУС-уудад тодорхойлсон, энэ СБПУ-ийн нэр томъёо	
Хавсралт Б: Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүнүүдийн хоорондох харилцан хамаарал	
Хавсралт В: Үзүүлэлтүүдийн нэр томъёоны тайлбар толь	
Дүгнэлтийн үндэслэл	

## Зорилт

1. Энэхүү Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ) нь улсын секторын байгууллагын санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг тайлагнах (“төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээллийг тайлагнах”<sup>1</sup>) талаархи заавар удирдамжаар хангана. СБПУ нь одоогийн бодлого ба тухайн тайлангийн өдрөөр гаргасан шийдвэрийн ирээдүйн орлогын болон зарлагын гүйлгээнд үзүүлэх үр нөлөөний талаархи мэдээллээр хангах бөгөөд нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (“санхүүгийн тайлан”) дахь мэдээллийн нэмэлт гүйцээлт болдог. Ийм тайлагналын зорилго нь тогтоосон таамаглалуудын дагуу хугацааны тодорхой хүрээнд уг байгууллагын төсөөлсөн санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлын үзүүлэлтээр хангах явдал юм.

## Төлөв байдал ба цар хүрээ

2. Энэхүү СБПУ-ийн дагуу хийгдэх мэдээллийн тайлагнал нь сайн практикыг илэрхийлнэ. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээллийг тайлагнаж буй байгууллага нь энэ СБПУ-ийг дагаж мөрдөхийг сайшаан дэмжинэ. Байгууллага нь өөрийн санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-д нийцсэн гэж мэдэгдэхийн тулд энэхүү СБПУ-ийг даган мөрдсөн байхыг шаардахгүй.
3. Энэхүү СБПУ-ийн цар хүрээнд тухайн байгууллагын төсөөлсөн гүйлгээ хамаарна. Энэ нь нийгмийн халамж үзүүлэх хөтөлбөрүүдтэй холбоотой гүйлгээгээр зөвхөн хязгаарлагдахгүй. Гэвч нийгмийн халамж үзүүлдэг хөтөлбөрүүдтэй, үүн дотроо оролцогчдын хувь оролцоог шаарддаг эрх олгох хөтөлбөрүүдтэй холбоотой гүйлгээ нь олон байгууллагуудын хувьд төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн тайлагналын хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг гэдгийг энэхүү СБПУ-аар хүлээн зөвшөөрдөг.
4. Байгаль орчны тогтвортой байдлын тайлагналтай холбоотой асуудлуудыг энэ СБПУ-д шууд авч үзээгүй болно. Гэвч байгууллага нь байгаль орчны хүчин зүйлсийн санхүүгийн аливаа үр нөлөөг үнэлэх ба өөрийн төсөөллийг бэлтгэхдээ тэдгээрийг харгалзах хэрэгтэй.
5. [Хассан]
6. Хэдийгээр энэхүү СБПУ нь улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудад шууд хамаарахгүй боловч уг тайлагнагч байгууллагын хяналтанд буй улсын секторын худалдаа арилжааны байгууллагатай холбоотой бөгөөд төсөөллийн тодорхой хугацааны хамрах хүрээн дэх

---

<sup>1</sup> Олон улс орны хувьд “төсөв” гэсэн нэр томъёо нь татвартай холбоотой явцуу тайлбартай байдаг болохыг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Энэхүү СБПУ-д уг нэр томъёог орлогын болон зарлагын гүйлгээний аль алиныг агуулах илүү өргөн утгатайгаар ашигласан.

ирээдүйн орлогын болон зарлагын гүйлгээ нь энэ СБПУ-ийн цар хүрээнд хамаарна.

7. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээлэл нь энэ СБПУ-ийн бүх шаардлагуудтай нийцсэн байхаас бусад тохиолдолд түүнийг энэ СБПУ-тай нийцсэн гэж тодорхойлж болохгүй.
8. Энэ СБПУ нь мэдээллийн хамгийн наад захын түвшинг тогтоодог. Нэмэлт мэдээлэл нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд ач холбогдолтой бөгөөд санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд (ЧШ-үүд)-ийг хангаж байвал тийм мэдээллийг толилуулахад энэхүү СБПУ саад учруулахгүй.

## **Тодорхойлолт**

9. Энэ СБПУ-д дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:

Одоогийн бодлогын таамаглал гэдэг нь тухайн тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль буюу зохицуулалтад үндэслэсэн бөгөөд тодорхойлсон нөхцөл байдлын хувьд зохих гажилтыг агуулсан таамаглалууд юм.

Орлогын гүйлгээ гэдэг нь уг төсөөллийн хугацааны хамрах хүрээнд тухайн байгууллагын хүлээн авахаар эсвэл хуримтлагдахаар төсөөлсөн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө юм.

Төсвийн урт хугацааны тогтвортой байдал гэдэг нь одоо болон ирээдүйн аль алинд үйлчилгээ үзүүлэх ба санхүүгийн амлалтаа биелүүлэх уг байгууллагын чадвар боломж юм.

Зарлагын гүйлгээ гэдэг нь уг төсөөллийн хугацааны хамрах хүрээнд тухайн байгууллагын төлөхөөр эсвэл хуримтлагдахаар төсөөлсөн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө юм.

Төсөөлөл гэдэг нь тухайн байгууллагын одоогийн бодлогын таамаглал, түүнчлэн ирээдүйн эдийн засгийн болон бусад нөхцөл байдлын талаархи таамаглалд үндэслэн бэлтгэсэн хэтийн санхүүгийн мэдээлэл юм.

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсон утгаар энэ СБПУ-д хэрэглэсэн бөгөөд Хавсралт А-д харуулсан.

## **Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнах эсэхийг тодорхойлох**

10. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнах эсэхийг тодорхойлохдоо, байгууллага нь уг хэтийн санхүүгийн мэдээллийн хувьд боломжит хэрэглэгчид оршин байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай.



11. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээлэл нь санхүүгийн тайлангийн мэдээллээс илүү өргөн хүрээтэй байдаг. Энэ нь тодорхой хугацааны хамрах хүрээнд одоогийн бодлогын таамаглалуудыг ашиглан хийсэн бараа, үйлчилгээний нийлүүлэлт болон нийгмийн халамж үзүүлэх хөтөлбөрүүдтэй холбоотой төсөөлсөн орлогын болон зарлагын гүйлгээг тусгадаг. Иймээс энэ нь тайлангийн өдөр буюу түүнээс өмнө тухайн байгууллагын гаргасан бөгөөд уг тайлангийн өдрөөр өр төлбөрийн тодорхойлолт ба/буюу хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй тийм ирээдүйн зарлагын гүйлгээ үүсэхэд хүргэх шийдвэрүүдийг харгалзан тусгадаг. Үүнтэй адилаар, энэ нь уг тайлангийн өдрөөр хөрөнгийн тодорхойлолт ба/буюу хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй тийм ирээдүйн орлогын гүйлгээг харгалзан тусгадаг.
12. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын үнэлгээнд янз бүрийн өргөн хүрээтэй тоон мэдээг ашигладаг. Эдгээр тоон мэдээнд ирээдүйн эдийн засгийн болон хүн ам зүйн нөхцөл байдлын талаархи санхүүгийн ба санхүүгийн бус мэдээлэл, түүнчлэн бүтээмж, үндэсний, мужийн, орон нутгийн эдийн засгийн харьцангуй өрсөлдөх чадвар гэх мэт улс орны болон олон улсын хандлага ба насжилт, нас баралт, өвчлөл, нөхөн үржихүй, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлтийн түвшин гэх мэт хүн ам зүйн хувьсагчдын хүлээгдэж буй өөрчлөлтийн талаархи таамаглалууд хамаардаг.
13. Үйлчилгээ үзүүлэх түвшинг тодорхойлохын тулд төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн тайлагналын хамааралтай байдлыг тухайн байгууллагын санхүүжилт болон чадавхийн хүрээнд харгалзан үзэх хэрэгтэй. Дараах нэг буюу хэд хэдэн шинж чанар бүхий байгууллагуудын хувьд төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн хэрэглэгчид байх магадлалтай юм:
  - (а) Татварын ба/буюу бусад мэдэгдэхүйц орлогыг бий болгох бүрэн эрхтэй;
  - (б) Мэдэгдэхүйц хэмжээний өр үүсгэх бүрэн эрхтэй; эсвэл
  - (в) Үйлчилгээний нийлүүлэлтийн, үүн дотроо шинэ үйлчилгээ нэвтрүүлэлтийн шинж төрөл, түвшин, аргыг тодорхойлох бүрэн эрх ба чадвар боломжтой.

## **Тайлагналын хил хязгаар**

14. Санхүүгийн тайлангийн хил хязгаартай ижил тайлагналын хил хязгаарыг ашиглах нь төсөөллийн ойлгомжтой байдлыг сайжруулж, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (НЗСТ)-гийн хэрэглэгчдэд түүний үзүүлэх ач холбогдлыг нэмэгдүүлдэг.
15. Байгууллага нь Засгийн Газрын Үндсэн Сектор (ЗГҮС) гэх мэт тайлагналын өөр хил хязгаарыг ашигласнаар төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнаж болно. Тайлагналын өөр хил хязгаарт үндэслэн төсвийн урт хугацааны тогтвортой байдлыг үнэлэхэд

ашигладаг өөр үзүүлэлтүүд байж болох учраас энэ нь бусад улс орнуудтай нийцэх ба зэрэгцүүлэгдэх боломжтой байдлыг сайжруулж болох юм. ЗГҮС-ын талаархи мэдээллээр хангадаг байгууллагууд нь УСНББОУС 22, *Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга*-ын дагуу мэдээллийг мөн толилуулахыг сайшаан дэмжинэ.

## **Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнах**

16. Энэхүү СБПУ-ийн дагуу бэлтгэсэн төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээлэл нь тухайн байгууллагын төсвийн урт хугацааны тогтвортой байдлын янз бүрийн төлөв, үүн дотроо уг байгууллагад учрах санхүүгийн эрсдлийн шинж төрөл ба хэмжээг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог.
17. Байгууллагын төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн хэлбэр ба агуулга нь тухайн байгууллагын шинж төрөл ба түүний үйл ажиллагаа явуулдаг зохицуулалтын орчноос хамааран янз бүр байдаг. Толилуулгын нэг хандлага нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангах магадлал багатай юм. Хязгаарлалтуудыг<sup>2</sup> харгалзахын зэрэгцээгээр санхүүгийн тайлагналын зорилтууд<sup>3</sup> болон ЧШ-үүийг хангахын тулд төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээлэл нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг ихэвчлэн агуулсан байдаг:
  - (а) Хүснэгтэн тайлан буюу график загвараар үзүүлж болох ирээдүйн орлогын болон зарлагын гүйлгээний төсөөлөл ба уг төсөөллийг тайлбарласан хүүрнэсэн хэлэлцүүлэг (21–26 ба 56-р параграфыг үзнэ үү);
  - (б) Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүнүүдийн хүүрнэсэн хэлэлцүүлэг, үүн дотроо тэдгээр хэмжигдэхүүнийг илэрхийлэхэд ашигласан аливаа үзүүлэлтүүд (27–40 ба 57-р параграфыг үзнэ үү); ба
  - (в) Төсөөллийн суурь үндэслэл болох зарчмууд, таамаглалууд ба арга зүйн талаархи хүүрнэсэн хэлэлцүүлэг (41–53 ба 58-р параграфыг үзнэ үү).

---

<sup>2</sup> Санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх шинжүүд юм. Мэдээллийн хязгаарлалтууд нь материаллаг байдал, өртөг-өгөөжийн тэнцвэр, чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр юм. Дэлгэрэнгүй мэдээллийг *Онолын Үзэл Баримтлалын* 3-р бүлгээс үзнэ үү.

<sup>3</sup> Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилтууд нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой тухайн байгууллагын талаархи мэдээллээр хангах явдал юм. Дэлгэрэнгүй мэдээллийг *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* (Онолын үзэл баримтлал)-ын 2-р бүлгээс үзнэ үү.

18. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээлэлд тайлагнасан төсөөлөл нь тодорхой бус нөхцөл байдлыг ерөнхийдөө тусгадаг. Зарим талаар тодорхой бус таамаглалуудад үндэслэсэн загваруудаас төсөөллийг бэлтгэдэг. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээлэл нь тухайн байгууллагын ирээдүйн төсөөлсөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэхийн тулд уг ашиглаж буй таамаглалууд нь бэлэн боломжтой байгаа хамгийн сайн мэдээлэлд үндэслэсэн байвал зохино.
19. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээллийг тусдаа тайлан эсвэл өөр тайлангийн нэг хэсэг байдлаар хэвлэж болно. Үүнийг тухайн байгууллагын НЗСТ-тай ижил хугацаанд эсвэл өөр хугацаанд хэвлэн гаргаж болно.
20. Уг тайлагнасан мэдээлэл нь түүний хяналт тавигч байгууллагын тайлагнасан мэдээлэлтэй нийцэж буй эсэхийг хяналтанд буй байгууллага нь ханган магадлах хэрэгтэй.

### **Ирээдүйн орлогын болон зарлагын гүйлгээний төсөөллийг толилуулах**

21. Байгууллага нь ирээдүйн орлогын болон зарлагын гүйлгээний, үүн дотроо капитал зарлагын төсөөллийг толилуулах хэрэгтэй. Төсөөллийг одоогийн бодлогын таамаглал, түүнчлэн ирээдүйн эдийн засгийн болон бусад нөхцөл байдлын талаархи таамаглалд үндэслэн бэлтгэдэг.
22. Байгууллага нь мэдээллийг өөрөө бэлтгэхийн оронд Сангийн яам гэх мэт бусад байгууллагын бэлтгэсэн буюу мэдээллийн бусад эх үүсвэрээс авсан таамаглал, төсөөлөл, үзүүлэлтийг ашигласнаар тайлагналын өртөг зардлыг бууруулж болох тул тэдгээрт үндэслэж болох хэмжээг үнэлэх хэрэгтэй. Ийм мэдээлэл нь ЧШ-үүдийг хангаж буй эсэхийг уг үнэлгээнд харгалзан үздэг. Байгууллага нь төсөөллийн тодорхойлолтыг хангах төсөв буюу прогнозтой байх тохиолдолд холбогдох тайлант үе буюу үеүдэд энэхүү мэдээллийг ашиглаж болно.
23. Зарлагын гүйлгээ үүсэхэд хүргэх хөтөлбөр, үйл ажиллагааны талаархи дэлгэрэнгүй мэдээллээр хангах ба орлогын гүйлгээний эх үүсвэрийг тодотгон харуулахын тулд төсөөллийг хүснэгтэн тайлан эсвэл график загвараар үзүүлж болно. Хүснэгтэн тайлангийн хэлбэрийг тодорхойлохдоо, байгууллагууд нь ойлгомжтой ба хамааралтай байдлын ач холбогдлын тэнцвэрийг хангах шаардлагатай юм. Тайлангийн өдөр ба хугацааны хамрах хүрээний төгсгөлийн хоорондох маш олон тайлант үеүд бүхий толилуулга нь илүү иж бүрэн цогц мэдээллээр хангадаг боловч хэт их мэдээлэл болон ойлгомжтой байдлыг алдагдуулах эрсдлийг нэмэгдүүлдэг.
24. Зориудаар тааламжтай эсвэл тааламжгүй дүр зургийг илэрхийлэхийн тулд тухайн төсөөллийн сонголт ба толилуулгыг гажуудуулаагүй гэдгийг байгууллага нь ханган магадалах хэрэгтэй. Ашигласан хэлбэр загвар ба нэр томъёо нь тайлант үеүд хооронд мөн тууштай байвал зохино.

### **Хугацааны хамрах хүрээ**

25. Хугацааны зохих хамрах хүрээг сонгохдоо, байгууллага нь шалгах боломжтой байх, үнэн зөв илэрхийлэх, хамааралтай байх гэсэн ЧШ-үүдийн тэнцвэрийг хангах шаардлагатай. Тухайн тайлангийн өдрөөс уг хугацааны хамрах хүрээний төгсгөл хүртэл илүү урт хугацаатай байх тусам ирээдүйн илүү олон үйл явдлыг харгалзан тусгадаг. Гэвч хугацааны хамрах хүрээ урт болохын хэрээр уг төсөөллийн суурь үндэслэл болсон таамаглалууд нь арай найдваргүй бөгөөд шалгах боломжтой байдал нь багасдаг. Харин эсрэгээр, хэт богино хугацааны хамрах хүрээ нь уг хүрээний гаднах үйл явдлуудын үр дагаврыг харгалзахгүй байх эрсдлийг нэмэгдүүлж, ингэснээр төсөөллийн хамааралтай байдлыг бууруулдаг.
26. Хугацааны хамрах хүрээний урт нь тухайн байгууллагын шинж чанарыг тусгадаг. Байгууллагын шинж чанарууд, үүн дотроо гол хөтөлбөрүүдийн үргэлжлэх хугацаа, санхүүжилтийн хувьд бусад байгууллагуудаас хараат байдлын түвшин, түүнчлэн дэд бүтцийн сүлжээ гэх мэт үндсэн хөрөнгийн гол зүйлсийн тооцоолсон ашиглалтын хугацаа, төсөөллийн мэдээллийг бэлтгэж буй бусад зэрэгцүүлэгдэх байгууллагуудын хэрэглэдэг хугацааны хамрах хүрээ зэрэг төлөв байдлууд нь хугацааны хамрах хүрээний уртад нөлөөлөх магадлалтай байдаг.

### **Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүнүүдийг авч үзэх**

27. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнаж буй байгууллага нь төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүн тус бүрийн хувьд хүүрнэсэн хэлэлцүүлгийг тусган оруулах хэрэгтэй. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хоорондоо харилцан холбоотой дараах гурван хэмжигдэхүүнийг энэхүү СБПУ-д авч хэлэлцсэн:
- Үйлчилгээ;
  - Орлого; ба
  - Өр.
28. Нэг хэмжигдэхүүний өөрчлөлт нь нөгөө хэмжигдэхүүнд нөлөөлдөг тул эдгээр хэмжигдэхүүнүүд нь хоорондоо харилцан холбоотой юм. Жишээлбэл; ирээдүйн үйлчилгээ ба өгөөжийг хүртэгчдэд эрх олголт (үйлчилгээний хэмжигдэхүүн)-ыг орлого ба/буюу өрөөр санхүүжүүлдэг. Нөгөө хоёр хэмжигдэхүүнийг тогтмол байлгаснаар нэг хэмжигдэхүүнийг шинжилж болно. Жишээлбэл; үйлчилгээ болон орлогын одоогийн түвшинг тогтмол байлгаснаар байгууллага нь өрийн түвшинд уг таамаглалын үзүүлэх үр нөлөөг харуулж болох юм. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүнүүдийн хоорондох хамаарлыг Хавсралт Б-д үлгэрчлэн харуулсан.
29. Хэмжигдэхүүн бүр нь чадамж ба эмзэг байдал гэсэн хоёр төлөв байдалтай байдаг. Чадамж нь тухайн хэмжигдэхүүнийг өөрчлөх буюу түүнд нөлөө

үзүүлэх байгууллагын чадвар, харин эмзэг байдал нь уг байгууллагын хяналт буюу нөлөөллөөс ангид хүчин зүйлсээс түүний хамааралтай байх хэмжээ юм.

30. Байгууллага нь төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүнүүдийг толилуулахын тулд үзүүлэлтүүдийг ашиглаж болно. Байгууллага нь түүнд хамааралтай байдалд үндэслэн өөрийн үзүүлэлтүүдийг сонгох хэрэгтэй. Үзүүлэлтүүдийн жишээг Хавсралт В дэх Үзүүлэлтүүдийн Тайлбар Тольд харуулсан.

#### **Үйлчилгээний хэмжигдэхүүн**

31. Өрийн хязгаарлалтыг хэвээр хадгалахын зэрэгцээгээр, татвар ба бусад эх үүсвэрээс олох орлогын талаархи одоогийн бодлогын таамаглалуудыг харгалзсанаар уг төсөөллийн хугацаанд хүлээн авагчдад үзүүлэх үйлчилгээ болон өгөөж хүртэгчдэд бүрдүүлэх эрх олголтын хэмжээ, чанарыг үйлчилгээний хэмжигдэхүүнд харгалзан үздэг. Энэ хэмжигдэхүүн нь байгууллагын үзүүлэх үйлчилгээ буюу түүний хэрэгжүүлэх эрх олгох хөтөлбөрийн тоо хэмжээ ба чанарыг хадгалах, эсвэл өөрчлөх уг байгууллагын чадамжид анхаарал хандуулдаг. Энэ нь үйлчилгээ буюу эрх олголтын бууруулалтыг тэдгээр хүлээн авагч болон өгөөж хүртэгч нар хүлээн зөвшөөрөх бэлэн байдал гэх мэт хүчин зүйлсэд уг байгууллагын эмзэг, эсвэл үйлчилгээний түвшинг тодорхойлох буюу өөрчлөх чадвар боломжгүйн улмаас, тухайлбал үзүүлэх үйлчилгээний түвшинг засгийн газрын өөр түвшин тодорхойлдог тохиолдолд эмзэг байх эсэхэд мөн анхаарал хандуулдаг.
32. Татварын ба бусад эх үүсвэрийн орлогод болон өрд одоогийн бодлогын таамаглалуудын үзүүлэх үр нөлөөг тусгаснаар, төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээлэл нь бараа, үйлчилгээний нийлүүлэлтийн хувьд бэлэн боломжтой байгаа дүнг тусган толилуулдаг. Хэрэглэгчид нь энэхүү мэдээллийг тухайн байгууллагыг үйлчилгээ үзүүлэх амлалттай харьцуулж, ингэснээр үйлчилгээний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг үнэлдэг.
33. Ийм харьцуулалт хийхэд харгалзан үзэх хүчин зүйл нь зарим хөтөлбөрийн зарлага уг байгууллагын зарлагын ерөнхий түвшнээс илүү хурдацтай өсөх магадлалтай байх хэмжээ юм. Энэ нь тухай хөтөлбөрийн хувьд өгөөж хүртэгчдийн тоо өсөхөөр төсөөлсөн, эсвэл эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэх мэт зарим хөтөлбөртэй холбоотой өртөг зардал нь инфляцийн ерөнхий түвшнээс илүү хурдацтай өсөхөөр төсөөлсөнтэй холбоотой байж болно. Жишээлбэл; хүн ам зүйн болон технологийн өөрчлөлтийн улмаас засгийн газрын нийт зарлагын хувийн жин байдлаар илэрхийлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өртөг зардал нь уг төсөөллийн хугацаанд өсөхөөр төсөөлж болох юм.
34. Капитал эрчимт үйл ажиллагааны хувьд, үйлчилгээний хэмжигдэхүүн нь үндсэн хөрөнгийн зүйлсийн ашиглалтын хугацаа ба орлуулалтын мөчлөгийн үнэлгээг бас агуулсан байдаг.

### Орлогын хэмжигдэхүүн

35. Орлогын хэмжигдэхүүн нь өрийн хязгаарлалтыг хэвээр хадгалахын зэрэгцээгээр, хүлээн авагчдад үзүүлэх үйлчилгээ болон өгөөж хүртэгчдэд бүрдүүлэх эрх олголтын талаархи одоогийн бодлогын таамаглалуудыг харгалзсанаар уг төсөөллийн хугацаанд татварын түвшин ба бусад орлогын эх үүсвэрийг харгалзан үздэг. Энэ хэмжигдэхүүн нь одоогийн татварын түвшин болон бусад орлогын эх үүсвэрийг өөрчлөх, эсвэл шинэ орлогын эх үүсвэр бүрдүүлэх уг байгууллагын чадамжид анхаарал хандуулдаг. Энэ нь татварын түвшний нэмэгдүүлэлтийг татвар төлөгч нар үл хүлээн зөвшөөрөлтийн хувьд тухайн байгууллага эмзэг байх эсэх, түүнчлэн уг байгууллагын хяналт буюу нөлөөллөөс ангид орлогын эх үүсвэрээс түүний хамааралтай байдлын хэмжээ гэх мэт хүчин зүйлсэд мөн анхаарал хандуулдаг.
36. Орлогын хэмжигдэхүүний үзүүлэлтийн жишээ нь засгийн газрын бусад түвшний байгууллагуудаас эсвэл олон улсын байгууллагуудаас хүлээн авсан орлогын нийт орлого дахь хувийн жин юм. Жишээлбэл; орон нутгийн засгийн газрын байгууллага нь үл хөдлөх хөрөнгийн татварын хэмжээг хэвээр хадгалах буюу нэмэгдүүлэх боломжтой боловч үндэсний ба/буюу мужийн засгийн газруудаас авах ерөнхий болон тусгай буцалтгүй тусламжаас зарим талаар хамааралтай байж болно. Үйлчилгээ үзүүлэх болон өрийг удирдах бодлогыг төсөөлдөг тул ийм бодлогуудыг санхүүжүүлэхэд шаардлагатай орлогын түвшинг толилуулж болох юм. Энэ мэдээлэл нь өөрийн орлогын түвшинг хэвээр хадгалах эсвэл нэмэгдүүлэх тухайн байгууллагын чадавхийг үнэлэх, ингэснээр түүний орлогын эх үүсвэрийн тогтвортой байдлыг үнэлэхэд хэрэглэгчдэд тусалдаг.
37. Ерөнхийдөө, татварын болон бусад эх үүсвэрийн орлогын түвшинг өөрчлөх хязгаарлагдмал чадвар боломж бүхий байгууллага нь засгийн газрын бусад түвшний байгууллагуудаас гаргах санхүүжилтийн шийдвэрээс ихээхэн хамааралтай байдаг. Засгийн газар хоорондын шилжүүлэг нь үндсэн хуулийн болон бусад хууль тогтоомжийн үндэслэлтэй тохиолдолд энэ нь бусад байгууллагуудаас санхүүжилтийн талаар гаргах гэнэтийн тааламжгүй шийдвэрт уг байгууллага арай бага өртөх, ингэснээр тогтвортой орлогыг үргэлжлүүлэн хүлээн авах магадлалыг нэмэгдүүлж болох юм. Энэхүү мэдээлэл нь тухайн байгууллагын хяналтаас ангид шийдвэрт түүний эмзэг байдлыг үнэлэхэд хэрэглэгчдэд тусалдаг.

### Өрийн хэмжигдэхүүн

38. Өрийн хэмжигдэхүүн нь хүлээн авагчдад үзүүлэх үйлчилгээ болон өгөөж хүртэгчдэд бүрдүүлэх эрх олголтын талаархи одоогийн бодлогын таамаглалуудыг харгалзсанаар уг төсөөллийн хугацаанд өрийн түвшинг харгалзан үздэг. Энэхүү хэмжигдэхүүн нь биелүүлэх хугацаа болох үед өөрийн санхүүгийн амлалтаа хэрэгжүүлэх, шаардлагатай бол өрийг дахин санхүүжүүлэх буюу нэмэгдүүлэх уг байгууллагын чадамжид анхаарал хандуулдаг. Энэ нь зах зээл, зээлдүүлэгчийн найдвартай байдал, хүүний түвшний эрсдэлд уг байгууллага эмзэг эсэхэд мөн анхаарал хандуулдаг.

39. Цэвэр өрийн түвшин нь ирээдүйд санхүүжүүлэх ёстой бараа, үйлчилгээний өмнөх нийлүүлэлтийн хувьд зарцуулсан дүнг илэрхийлдэг учраас аливаа тайлангийн өдрөөрх өрийн хэмжигдэхүүний үнэлгээнд чухал ач холбогдолтой байдаг. Иймээс энэ үзүүлэлт нь олон байгууллагад хамааралтай байх магадлалтай юм. Бараа, үйлчилгээний нийлүүлэлт, түүнчлэн татварын болон бусад эх үүсвэрийн орлогын хувьд одоогийн бодлогын таамаглалуудыг төсөөлснөөр, цэвэр өрийн төсөөлсөн түвшинг толилуулдаг. Энэхүү мэдээлэл нь биелүүлэх хугацаа болох үед өөрийн санхүүгийн амлалтаа хэрэгжүүлэх, өрийн түвшинг хэвээр хадгалах, дахин санхүүжүүлэх буюу нэмэгдүүлэх уг байгууллагын чадвар боломжийг үнэлэх, ингэснээр уг байгууллагын өрийн тогтвортой байдлыг үнэлэхэд хэрэглэгчдэд тусалдаг.
40. Үндэсний түвшинд уг төсөөллийг толилуулахад харгалзах хүчин зүйл нь дараах үзүүлэлтийг өөр хооронд нь ялган тодорхойлсон эсэх юм: (а) суурь тэнцэл, энэ нь засгийн газрын төсөөлсөн нийт зарлагаас татварын орлогыг хассан дүн бөгөөд үүнд өрийн хүүний өглөгийг оруулан тооцохгүй, ба (б) нэгдсэн тэнцэл, энэ нь өрийн хүүний өглөгийг оруулан тооцсон суурь тэнцэл юм. Үндэсний дэд түвшнүүд болон олон улсын байгууллагуудын хувьд гол анхаарах зүйл нь нийт орлогын хувийн жингээр илэрхийлэгдэх цэвэр өр байж болох юм. Энэ үзүүлэлтийн өсөлт нь өрийг барагдуулахад шаардлагатай орлогын өсөн нэмэгдсэн хувь хэмжээг, түүнчлэн үйлчилгээний нийлүүлэлтээс бий болох нөөцийг өөр зүйлд зарцуулах ба тухайн байгууллагын өрийн төсөөлсөн түвшин өөрчлөгдөж болохыг харуулдаг.

## **Зарчим ба арга зүй**

### **Төсөөлөл ба тайлагналын давтамжийг шинэчлэн баяжуулах**

41. Байнгын шинэчлэн баяжуулалт хэрэгтэй боловч бүх байгууллагын хувьд жил бүр шинэчлэн баяжуулалт хийх бодит боломжгүй байж болно гэдгийг энэхүү СБПУ-д хүлээн зөвшөөрсөн. Гэвч төсөөллийн суурь үндэслэл болох таамаглалуудын найдвартай байдал ба төсөөллийг хийснээс хойшхи хугацааны уртын хооронд ерөнхийдөө урвуу хамааралтай байдаг. Дэлхийн санхүүгийн тогтворгүй байдлын үед тухайн тайлангийн өдрөөс тодорхой хугацааны өмнө хийсэн төсөөлөл нь хуучрах, ингэснээр хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилтуудыг хангах уг мэдээллийн чадвар боломж дагалдан буурах эрсдэл нэмэгддэг. Ийм нөхцөл байдалд байгууллага нь өөрийн төсөөллийг илүү ойрхон давтамжтайгаар шинэчлэн баяжуулах эсэхийг харгалзан үзвэл зохино. Байгалийн гамшиг болон бусад онцгой зүйлс гэх мэт урьдчилан хүлээгдээгүй томоохон буюу чухал үйл явдлын дараа, байгууллага нь өөрийн төсөөллийг мөн шинэчлэн баяжуулахаар харгалзан үзэх хэрэгтэй.

### **Хуулийн шаардлагууд ба бодлогын хүрээний үр нөлөө**

42. Зарим улс оронд, төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн тайлагналыг үндэсний болон мужийн түвшинд мөрддөг хууль

буюу зохицуулалтаар, эсвэл олон улсын хэлэлцээрээр зохицуулдаг. Орон нутгийн засаг захиргаанд зориулсан хуулийн шаардлагууд бас байж болно. Үүнд: тэнцвэржүүлсэн төсвийн шаардлагууд хамаарч болох юм. Эдгээр шаардлагууд нь өөрийн төсөөллийг тооцоолж, тодруулахдаа тухайн байгууллагын ашиглавал зохих зарчим, таамаглал, арга зүйг тусгайлан заасан буюу тэдгээрт өөр бусад байдлаар нөлөөлөх магадлалтай байдаг.

### **Одоогийн бодлого, хүн ам зүйн болон эдийн засгийн таамаглалууд**

43. Тодорхой хөтөлбөр ба үйл ажиллагааны гүйлгээг бие даасан байдлаар загварчилдаг тохиолдолд бодлогын таамаглалууд нь одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж буюу зохицуулалтанд зохих гажилттайгаар үндэслэсэн байвал зохино. Тэдгээр таамаглалуудыг (“одоогийн бодлогын таамаглал” гэж нэрлэдэг) уг төсөөллийн нийт хугацааны туршид тууштай мөрдөх хэрэгтэй. Одоогийн бодлогын таамаглалыг эхлэлийн цэг нь одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж буюу зохицуулалт юм. Гэвч одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалтаас гажих нь тохиромжтой байх тийм тохиолдол байж болох юм. Тухайлбал;
  - (а) Одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалтын өөрчлөлтийг тухайн тайлангийн өдрөөс өмнө баталсан ба тэдгээр өөрчлөлт нь уг төсөөллийн хугацааны хамрах хүрээн дэх хэрэгжих тогтоосон өдөртэй байх;
  - (б) Одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалтын зүйл заалтууд нь дотроо зөрчилтэй байх; эсвэл
  - (в) Одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалт нь дуусгавар болох өдөртэй, жишээлбэл “өндөрлөх” заалттай байх.
44. Одоогийн бодлогын таамаглалуудад тухайн тайлангийн өдрөөс өмнө баталсан ба уг төсөөллийн хугацааны хамрах хүрээн дэх хэрэгжих тогтоосон өдөр бүхий хуулийн өөрчлөлтүүд нөлөө үзүүлж болох юм. Ийм тохиолдолд одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалтыг уг төсөөллийн нийт хугацаанд хүчин төгөлдөр хэвээр байна гэж үзэх нь тохиромжгүй юм.
45. Дотроо зөрчилтэй одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалтын жишээ нь; тухайн тэтгэмж авагчийн эрх нь уг мөнгө сан дууссаны дараа ч үргэлжилсэн хэвээр байх боловч зориулагдсан мөнгө сан дуусмагц төлбөр хийхийг хууль бус гэж үздэг тийм хуулийн заалт бүхий нийгмийн хамгааллын хөтөлбөр юм. Мөнгө сан дууссанаар уг сан өөрийн үүргийг цаашид гүйцэтгэхгүй гэж үзэх нь хуулийн хатуу байр суурийг тусган илэрхийлж болох боловч ийм үндэслэлээр төсөөллийг бэлтгэх нь төсөөлсөн зарлагын гүйлгээг, түүнчлэн тухайн нийгмийн хамгааллын хөтөлбөрт тулгарч буй төсвийн шаардлагын хэмжээг дутуу тооцож буй эсэхийг байгууллага нь үнэлэх шаардлагатай байж болох юм. Ийм нөхцөл байдалд байгууллага нь хуулийн хязгаарлалтыг үл харгалзан одоогийн бодлогын таамаглалуудад үндэслэн өөрийн төсөөллийг тооцоолж болно.
46. Одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалт нь дуусгавар болох өдөртэй, жишээлбэл “өндөрлөх” заалттай, ингэснээр тодорхой хугацааны дараа



дуусгавар болдог байж болно. Олон тохиолдолд ийм хөтөлбөрүүдийг ижил төсөөтэй хөтөлбөрөөр орлуулах өндөр магадлалтай байж болох юм. Дуусгавар болгох хуулийн хатуу зарчмыг баримтлах нь төсөөлсөн зарлагын гүйлгээг дутуу тооцоолох, ингэснээр уг мэдээллийн ач холбогдлыг бууруулж болох юм.

*Орлогын гүйлгээний хандлага*

47. Татвараас, түүнчлэн засгийн газар хоорондын шилжүүлэг гэх мэт бусад эх үүсвэрээс орох орлогын томоохон гүйлгээнүүдийг одоогийн бодлогын таамаглалд үндэслэн тус тусад нь загварчилж болох юм. Тус тусад нь загварчлаагүй татварын болон бусад томоохон эх үүсвэрийн орлогын гүйлгээг дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) буюу тусгайлан заасан инфляцийн индекс гэх мэт хувьсагчтай харьцуулан нэмэгдэхээр (эсвэл буурахаар) төсөөлдөг.
48. Байгалийн нөөцийн эрхийн шимтгэл гэх мэт бусад орлогын гүйлгээг ДНБ буюу индексийн түвшинтэй уялдуулан мөн өсөхөөр төсөөлж болно. Байгалийн нөөц шавхагдан барагдахаар хүлээгдэж буй тохиолдол гэх мэт тусгай нөхцөл байдлыг харгалзахын тулд эдгээрийг тус тусад нь мөн загварчилж болно.

*Насжилттай холбоотой болон насжилттай холбоогүй хөтөлбөрүүдийн хандлага*

49. Насжилттай холбоотой хөтөлбөрүүд нь нас ба хүн ам зүйн бусад хүчин зүйлс гэх мэт зохих шалгуурт ихэвчлэн захирагддаг. Төсөөллийг хийхдээ, насжилттай холбоотой хөтөлбөр, үйл ажиллагааг насжилттай холбоогүй хөтөлбөрүүдээс ялган салгаж болох юм. Насжилттай холбоогүй хөтөлбөрүүдийг ДНБ гэх мэт бусад хувьсагчидтай уялдуулан өсөхөөр эсвэл бодит дүнгээрээ тогтмол байхаар төсөөлж болох боловч насжилттай холбоотой хөтөлбөрүүдийг тус тусад нь загварчилж болно. ДНБ/бодит дүнгийн өсөлтөөс давсан зарим хөтөлбөр, үйл ажиллагааны өсөлт нь бусад талбаруудын арай бага өсөлт буюу зарцуулалтын бууралтаар нөхөгдөх боломж олгодог учраас насжилттай холбоогүй хөтөлбөрийн ийм хандлага нь илүү уян хатан байдаг.

*Хүн ам зүйн болон эдийн засгийн таамаглалууд*

50. Хүн ам зүйн таамаглал нь төрөлт, нас баралт, шилжилт хөдөлгөөн, ажил эрхлэлтийн түвшинг агуулсан байх магадлалтай юм. Эдийн засгийн таамаглал нь эдийн засгийн өсөлтийн түвшин ба инфляцийг агуулах магадлалтай байдаг. Эдийн засгийн бусад таамаглал нь эдийн засгийн өсөлтөнд экологийн системийн бууралт ба доройтол, түүнчлэн усны болон үл сэргээгдэх байгалийн нөөцийн шавхагдлын үзүүлэх үр нөлөө гэх мэт байгаль орны хүчин зүйлсийг агуулсан байж болно.

*Таамаглалын ул үндэслэлтэй байдал*

51. Орлогын болон зарлагын гүйлгээний төсөөлөл нь 18-р параграфт авч хэлэлцсэн, хүчин зүйлсийн хүрээнд ул үндэслэлтэй байх одоогийн бодлогын таамаглалууд, эдийн засгийн ба хүн ам зүйн таамаглалуудад үндэслэсэн байвал зохино.

**Инфляци ба дискаунтын хувь**

52. Үнийн инфляцийн үр нөлөөг тухайн төсөөлөлд нэгтгэн тусгах хоёр гол хандлага байдаг. Төсөөллийг хийхдээ инфляцийг харгалзан тооцож эсвэл төсөөллийг одоогийн үнээр (өөрөөр хэлбэл, тухайн тайлангийн өдрөөр давамгайлах үнээр) хийж болох юм. Хэрэв төсөөлөлд инфляцийг тусган оруулсан бол дискаунтын хувьд мөн инфляцийг тооцож оруулах хэрэгтэй. Хэрэв төсөөллийг одоогийн үнээр хийсэн бол дискаунтын хувьд инфляцийг харгалзахгүй.

**Мэдрэмжийн шинжилгээ**

53. Төсөөллийн үндэслэл болох олон таамаглал нь угаасаа тодорхойгүй байдаг. Зарим тохиолдолд хувьсагчдын багахан өөрчлөлт нь тухайн төсөөлөлд мэдэгдэхүйц нөлөөтэй байж болно. Мэдрэмжийн шинжилгээг ашиглах нь тухайн төсөөлөлд хүн ам зүйн болон эдийн засгийн таамаглалуудын мэдэгдэхүйц өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөөг ойлгоход хэрэглэгчдэд тусалдаг.

**Тодруулга**

54. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн хэрэглэгчид нь тухайн байгууллагын төсөөлсөн төсвийн урт хугацааны тогтвортой байдлыг үнэлэх боломж олгох тийм мэдээллийг уг байгууллага нь тодруулах хэрэгтэй. Байгууллага нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахад шаардлагатай аливаа нэмэлт тодруулгыг хийвэл зохино.
55. Байгууллага нь дараах мэдээллийг тодруулна:
- (а) Байгууллагын нэр;
  - (б) Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээлэл хамаарах тухайн санхүүгийн тайлан;
  - (в) Санхүүгийн тайлангийн хувьд хамаарах нэрнээс өөр байх тохиолдолд төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн тайлагналын хил хязгаарт хамаарах байгууллагуудын нэрс;
  - (г) Байгууллага нь хяналтанд буй байгууллага байх тохиолдолд хяналт тавигч байгууллагын тайлбар тодорхойлолт;
  - (д) Бүрэн цогц төсөөллийг бэлтгэж гаргасан огноо;

БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

- (е) Уг бүрэн цогц төсөөллийн дараагийн шинэчлэн баяжуулалтын үндэслэл ба хугацаа; ба
  - (ж) Байгууллага нь бусад байгууллагуудын бэлтгэсэн буюу мэдээллийн бусад эх үүсвэрээс авсан төсөөлөл болон үзүүлэлтүүдийг ашигладаг тохиолдолд тэдгээр байгууллагууд буюу бусад эх үүсвэрийн нэрс ба ашигласан мэдээлэл.
56. Төсөөллийн хүүрнэсэн тайлбарт дараах мэдээллийн тодруулгыг тусгавал зохино:
- (а) Татварын болон бусад эх үүсвэрээс орсон томоохон орлогын гүйлгээний эх үүсвэр;
  - (б) Татварын болон бусад эх үүсвэрээс орсон томоохон орлогын гүйлгээний хувьд татварын босго шалгуур ба хөнгөлөлт гэх мэт одоогийн бодлогын таамаглалуудын тойм;
  - (в) Томоохон зарлагын, үүн дотроо капитал зарлагын эх үүсвэр;
  - (г) Томоохон зарлагын, үүн дотроо капитал зарлагын одоогийн бодлогын таамаглалуудын тойм;
  - (д) Төсөөллийг тус тусад нь, эсвэл нэгтгэн нийлүүлсэн байдлаар загварчилсан эсэх;
  - (е) Тайлангийн өдрүүдийн хооронд уг төсөөлөлд гарсан өөрчлөлтийн тайлбар ба тэдгээр өөрчлөлтийн шалтгаан;
  - (ж) Тухайн төсөөлөл нь прогноз биш бөгөөд тодорхой хугацааны хамрах хүрээ дэх төсөөллүүд нь гүйцэтгэлийн үр дүнтэй тохирох магадлал багатай, түүнчлэн зөрүүгийн хэмжээ нь янз бүрийн хүчин зүйлсээс, үүн дотроо төсвийн тодорхойлсон аливаа шаардлагыг биелүүлэх уг байгууллагын ирээдүйн үйл ажиллагаанаас хамаарах талаархи тайлбар;
  - (и) Тайлант үеүдийн хоорондох хэлбэр загварын аливаа өөрчлөлтийн тайлбар ба ийм өөрчлөлтийн шалтгаан;
  - (к) Төсөөлөлд ашигласан хугацааны хамрах хүрээ ба уг хугацааны хамрах хүрээг сонгосон шалтгаан; ба
  - (л) Байгууллага нь өмнөх тайлант үед ашиглаж байсан хугацааны хамрах хүрээг өөрчилсөн тохиолдолд ийм өөрчлөлтийн шалтгаан.
57. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүнүүдийн хүүрнэсэн тайлбарт дараах мэдээллийн тодруулгыг тусгасан байвал зохино:
- (а) Өмнөх тайлант үеийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад тэдгээр үзүүлэлтүүдэд гарсан мэдэгдэхүйц өөрчлөлтийн шинжилгээ;
  - (б) Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээллийг тайлагнахад ашигладаг үзүүлэлтүүдэд өмнөх тайлант үеэс хойш гарсан өөрчлөлтүүд ба тэдгээр өөрчлөлтийн шалтгаан; ба

- (в) Байгууллага нь УСНББОУС-тай нийцээгүй мэдээллээс бэлтгэсэн дүнгүүдэд үндэслэсэн үзүүлэлтүүдийг ашигладаг тохиолдолд энэ тухай болон уг хамаарах үзүүлэлтүүд.
58. Байгууллага нь төсөөллийн үндэслэл болох зарчим, таамаглал, арга зүйг, үүн дотроо дараах мэдээллийг тодруулах хэрэгтэй:
- (а) Удирдан чиглүүлэх хууль тогтоомж болон зохицуулалтын гол төлөв байдлууд;
- (б) Үндэслэл болох макро эдийн засгийн бодлого ба төсвийн үзэл баримтлал, үүн дотроо эдгээр бодлого ба үзэл баримтлалын талаархи олон нийтэд нээлттэй танилцуулдаг бусад тайланг, түүнчлэн НЗСТ-д үл хамаарах баримт бичгийг хянан үнэлдэг тохиолдолд тэдгээрийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл.
- (в) Төсөөллийн үндэслэл болох одоогийн гол бодлогын таамаглалууд, түүнчлэн хүн ам зүйн болон эдийн засгийн гол таамаглалууд;
- (г) Одоогийн бодлогын таамаглалууд, түүнчлэн хүн ам зүйн болон эдийн засгийн таамаглалуудыг нягталж шалгах ба шинэчлэн баяжуулах түүний бодлого;
- (д) Хүчин төгөлдөр хууль тогтоомж буюу зохицуулалтаас гажих одоогийн аливаа чухал бодлогын таамаглалуудын талаархи тайлбар;
- (е) Зарчим, таамаглал, арга зүйд өмнөх тайлант үеэс хойш орсон томоохон өөрчлөлтүүдийн тайлбар, тэдгээр өөрчлөлтүүдийн шинж төрөл ба хэмжээ, уг өөрчлөлтийн учир шалтгаан;
- (ж) Тухайн төсөөлөлд мэдэгдэхүйц үр нөлөөтэй байж болох аливаа мэдрэмжийн шинжилгээний үр дүн;
- (и) Ашигласан дискуантын хувь ба уг дискуантын хувийг тодорхойлсон суурь; ба
- (к) Инфляцийн хувьд баримталсан хандлага ба уг хандлагын шалтгаан.


**Хавсралт А****УСНББОУС-уудад тодорхойлсон, энэ СБПУ-ийн нэр томъёо**

<b>Нэр томъёо</b>	<b>Тодорхойлолт</b>
<b>Хөрөнгө</b>	Өнгөрсөн үйл явдлын үр дүнд байгууллага хяналтандаа оруулсан бөгөөд түүнээс уг байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болохоор хүлээгдэж буй нөөц юм.
<b>Мөнгө</b>	Бэлэн мөнгө ба харилцах данснаас бүрдэнэ.
<b>Мөнгөтэй адилтгах хөрөнгө</b>	Үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, ихээхэн өндөр хөрвөх чадвартай хөрөнгө оруулалт юм.
<b>Хяналтанд буй байгууллага</b>	Өөр байгууллагын (хяналт тавигч байгууллага гэж нэрлэгдэх) хяналтанд байдаг байгууллага, үүн дотроо нөхөрлөл гэх мэт хувь нийлүүлсэн хөрөнгөгүй байгууллага хамаарна.
<b>Хяналт тавигч байгууллага</b>	Нэг буюу хэд хэдэн байгууллагыг хянадаг байгууллага юм.
<b>Засгийн газрын үндсэн сектор</b>	Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудад тодорхойлсон, төв засгийн газрын бүтэц зохион байгуулалтанд хамаарах бүх байгууллагуудаас бүрдэнэ.
<b>Өр төлбөр</b>	Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн уг байгууллагын одоогийн үүрэг бөгөөд түүнийг барагдуулсанаар эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөц тухайн байгууллагаас гарахаар хүлээгдэж байдаг.
<b>Тайлангийн өдөр</b>	Тухайн санхүүгийн тайлангийн хамаарах тайлант үеийн сүүлчийн өдөр байна.
<b>Орлого</b>	Эздээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээ юм.

## Хавсралт Б

### Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүнүүдийн хоорондох харилцан хамаарал

Гурван хэмжигдэхүүн тус бүрийн хоёр төлөв байдал (чадамж ба эмзэг байдал) болон тэдгээр гурван хэмжигдэхүүнүүдийн хоорондох хамаарлыг энэхүү Хавсралтад үлгэрчлэн харуулсан.



## Хавсралт В

### Үзүүлэлтүүдийн нэр томъёоны тайлбар толь

Үзүүлэлтүүдийн жишээг энэ Хавсралтад жагсаан харуулсан. Энэ нь бүгдийг багтаасан жагсаалт биш юм.

#### Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн Тайлагналын Удирдамж

Үзүүлэлт нь тодорхойлсон нэр томъёог агуулдаг тохиолдолд уг нэр томъёог ташуу үсгээр илэрхийлж, түүний тайлбарыг тухайн үзүүлэлтийн дараа харуулсан.

- **Нийт өр, нийт өрийн дүн:** “Нийт өр” эсвэл “нийт өр төлбөр” гэж ихэвчлэн нэрлэдэг нийт өрийн дүн нь *өрийн хэрэглүүрүүд* болох бүх *өр төлбөрөөс* бүрддэг. Зээлдүүлэгчид ирээдүйн тодорхой өдөр эсвэл өдрүүдэд хүү ба үндсэн дүнг төлөхийг зээлдэгчээс шаарддаг санхүүгийн нэхэмжлэл гэж өрийн хэрэглүүрийг тодорхойлдог.<sup>4</sup>
- **Цэвэр өр:** Нийт өрөөс тухайн *өрийн хэрэглүүрт* хамаарах *санхүүгийн хөрөнгийг* хасаж, цэвэр өрийг тооцоолдог.<sup>4</sup>
- **Цэвэр санхүүгийн хөрөнгө:** *Байгууллагын нэгжийн* (эсвэл нэгжүүдийн бүлгийн) цэвэр санхүүгийн хөрөнгө нь түүний *санхүүгийн хөрөнгийн* нийт үнэ цэнээс түүний төлөгдөөгүй байгаа *өр төлбөрийн* нийт үнэ цэнийг хассан дүн юм.<sup>4</sup>
- **Цэвэр өмч:** *Байгууллагын нэгжийн* (эсвэл нэгжүүдийн бүлгийн) цэвэр өмч нь түүний *хөрөнгүүдийн* нийт үнэ цэнээс түүний төлөгдөөгүй байгаа *өр төлбөрийн* нийт үнэ цэнийг хассан дүн юм.<sup>4</sup>
- **Нэгдсэн тэнцэл:** Энэхүү нэр томъёо нь ЗГСС 1986-гийн “Нэгдсэн алдагдал/ашиг” томъёололд хамаарах бөгөөд орлого дээр хүлээн авсан буцалтгүй тусламжийг нэмж, зарлагыг хасаж, “олгосон зээлээс буцаан төлөлтийг хассан дүн”-г хасаж, үүнийг тодорхойлдог. Ингэж тодорхойлсон үлдэгдэл нь засгийн газрын авсан цэвэр зээл дээр засгийн газрын бэлэн мөнгө, харилцах данс болон хөрвөх чадварын зорилгоор эзэмшиж буй үнэт цаасны цэвэр бууралтыг нэмсэн нийлбэртэй тэнцүү (сөрөг утгатай) байна. Энэхүү тэнцлийн ухагдахууны үндэслэл нь засгийн газар бодлогын үр дүнд алдагдал эсвэл ашиг үүсэх явдал бөгөөд иймээс тэдгээр бодлоготой холбоотой орлого эсвэл зарлага нь “хязгаар шугамаас дээгүүр” байдаг. Харин авсан зээл буюу хөрвөх хөрөнгийн бууралт нь алдагдлын санхүүжилт буюу “хязгаар шугамаас доогуур” байна. Уг хязгаар шугамаас дээгүүр тусгасан “олгосон зээлээс буцаан төлөлтийг хассан дүн” нэр томъёо нь хөрвөх чадварын удирдлага буюу өгөөж олох зорилгоор биш, харин төрийн бодлогын зорилгоор гүйцэтгэж, бусад талуудаас засгийн

---

<sup>4</sup> Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан: *Улсын Секторын Өрийн Статистик – Эмхлэн бэлтгээгч ба хэрэглээгч нарт зориулсан заавар* 2011 он.

газрын шаардах өрийн болон өмчийн нэхэмжлэлийн ажил гүйлгээг агуулдаг.<sup>5</sup>

- **Суурь тэнцэл:** Хүүний төлбөрийг оруулаагүй нэгдсэн тэнцэл юм. Хүүний төлбөр нь өмнөх өрийн өртөг зардлыг илэрхийлдэг бөгөөд засгийн газрын бодлогын хяналтанд байгаа ирээдүйн өрийн тодорхойлогч нь хүүний төлбөрийг оруулаагүй бусад зарцуулалт ба орлогын хэмжүүр учраас суурь тэнцэл нь өрийн өндөр түвшинтэй улс орнуудын төсвийн байдлыг илэрхийлэх чухал ач холбогдолтой үзүүлэлт юм.<sup>5</sup>

#### *Суурь тодорхойлолтууд*

- **Өрийн хэрэглүүр:** Зээлдүүлэгчид ирээдүйн тодорхой өдөр эсвэл өдрүүдэд хүү ба үндсэн дүнг төлөхийг зээлдэгчээс шаарддаг санхүүгийн нэхэмжлэл гэж өрийн хэрэглүүрийг тодорхойлдог.<sup>4</sup>
- **Эдийн засгийн хөрөнгө:** Эдийн засгийн хөрөнгө гэдэг нь (i) түүний эдийн засгийн өмчлөлийн эрхийг байгууллагын нэгжүүд тус тусдаа эсвэл хамтдаа хэрэгжүүлдэг, (ii) түүнийг эзэмших буюу ашигласнаар эзэд нь цаг хугацааны явцад эдийн засгийн үр өгөөж хүртдэг байгууллагууд юм.<sup>4</sup>
- **Санхүүгийн хөрөнгө:** Санхүүгийн хөрөнгө нь санхүүгийн нэхэмжлэл дээр төв банкны нөөц хөрөнгө байдлаар эзэмшиж буй алтыг нэмсэн дүнгээс бүрддэг. Санхүүгийн нэхэмжлэл гэдэг нь мөнгө сан буюу бусад нөөцийг өр төлбөрийн нөхцлийн дагуу өөр байгууллагаас авах эрхийг хөрөнгийн эздэд (зээлдүүлэгчид) ихэвчлэн олгодог хөрөнгө юм.<sup>6</sup>
- **Байгууллагын нэгж:** Байгууллагын нэгж гэдэг нь өөрийн эрхийн хүрээнд хөрөнгийг эзэмших, өр төлбөр үүсгэх, бусад байгууллагуудтай эдийн засгийн үйл ажиллагаа ба ажил гүйлгээ эрхлэх чадавхи бүхий эдийн засгийн байгууллага юм.<sup>6</sup>
- **Өр төлбөр:** Нэг нэгж (зээлдэгч) нь нөгөө байгууллагад (зээлдүүлэгч) тодорхой нөхцлийн дагуу мөнгө сан буюу бусад нөөцийг олгох үүрэг хүлээсэн тохиолдолд өр төлбөр үүсдэг.<sup>6</sup>

#### **Бусад эх сурвалж**

- **Төсвийн цоорхой:** Төсвийн цоорхой гэдэг нь улсын өрийг дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий зорилтот хувь хэмжээнд буюу түүнээс бага байлгахад шаардлагатай хүүгүй зарлага ба/буюу орлогын өөрчлөлт юм.<sup>7</sup>

---

<sup>5</sup> Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан: *Төсвийн Ил Тод Байдлын Гарын Авлага* (2007 он).

<sup>6</sup> Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан: *Улсын Секторын Өрийн Статистик – Эмхлэн бэлтгэгч ба хэрэглэгч нарт зориулсан заавар* 2011 он.

<sup>7</sup> ДНБ гэдэг нь тухайн тайлант хугацаанд дотооддоо үйлдвэрлэсэн бүх эцсийн бараа, үйлчилгээний нийт зах зээлийн үнэ цэнэ юм. ДНБ-ний бүрэлдэхүүн хэсгүүд нь: хувийн хэвшлийн зарлага ба хөрөнгө оруулалт, засгийн газрын зарлага ба хөрөнгө оруулалт, цэвэр экспорт (экспорт - импорт) юм.



Илүү тодруулвал, төсвийн цоорхой нь тухайн тогтоосон төсөөллийн хугацаанд улсын өрийг ДНБ-ний зорилтот хувь хэмжээнд эсвэл түүнээс бага байлгахад шаардлагатай улсын өрийн бууралтаар (өсөлтөөр) тохируулга хийсэн, уг төсөөлсөн зарлагаас төсөөлсөн орлогыг хассан цэвэр дүн<sup>8</sup> юм. (Эх сурвалж: АНУ-ын Холбооны Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөлдөх Зөвлөл: Холбооны Улсын Санхүүгийн Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарын Тунхаглал 36: *АНУ-ын Засгийн Газрын Урт Хугацааны Дэлгэрэнгүй Төсөөлөл 2009*).

- **Төсвийн хугацааны хязгаарлалт:** Хэрэв засгийн газрын ирээдүйн бүх орлогын дискуантчилсан үнэ цэнэ нь тухайн засгийн газрын төсөөлсөн зарлагыг (улсын одоогийн өр ба ирээдүйн бүх зарлагын, үүн дотроо насжилттай холбоотой зарлагын төсөөлсөн өсөлтийн дискаунтчилсан үнэ цэнэ) нөхөж байвал төсвийн хугацааны хязгаарлалт хангагдана. (Эх сурвалж: Европын Комисс: *Тогтвортой Байдлын Тайлан: 2009 он*).
- **Цэвэр өр/Нийт орлого:** Нийт орлогын хувийн жин байдлаар илэрхийлсэн цэвэр өр. (Эх сурвалж: Канадын Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Зөвлөл (КУСНББЗ): Санал Болгосон Практик Тунхаглал 4 (СБПТ 4), *Санхүүгийн Байдлын Үзүүлэлтүүд: 2009 он*).

---

<sup>8</sup> Хүүг өнөөгийн үнэ цэнийн тооцоололд оруулдаг учраас зарлагын хувийн жин болох төсвийн цоорхойг хүү оруулаагүй зарлагын (“хүүгүй зарлагын”) хувийн жин байдлаар илэрхийлдэг.

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь СБПУ 1-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Оршил

- ДҮ1. УСНББОУСЗ нь нийгмийн бодлогын үүргийн (хожим нийгмийн халамж гэж өөрчлөн нэрлэсэн) тайлагналын төслийг 2002 онд анх санаачилж эхлүүлсэн. Энэ нь Саналын Урилга (СУ), *Засгийн Газруудын Нийгмийн Бодлогын Тайлагнал*-ыг 2004 оны 01 дүгээр сард хэвлэн гаргахад хүргэсэн. Уг СУ-д ирүүлсэн хариултуудыг шинжилсэний дараа УСНББОУСЗ нь нийгмийн халамжийн янз бүрийн дэд ангиллуудтай холбоотой үүргийн тайлагналд зориулсан саналуудыг боловсруулж эхэлсэн. Өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтийн агшин ба хэмжилтийн шаардлагуудын талаар зөвшилцөлд хүрч чадаагүйн улмаас 2006 оны сүүлчээр УСНББОУСЗ нь хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн хувьд цаашдын саналуудыг одоохондоо боловсруулахгүй байхаар шийдвэрлэсэн.
- ДҮ2. Завсарын алхам болгон УСНББОУСЗ нь тухайн тайлангийн өдрөөр мөнгөн шилжүүлэг (мөнгөөр олгох халамж)-ийн шалгуур хангаж буй этгээдэд шилжүүлэх дүнгийн тодруулга хийх саналыг боловсруулсан. УСНББОУСЗ нь үүрэг ба өр төлбөрийн тодруулгыг шууд санал болгоогүй. 2008 оны 3 дугаар сард СТ 34, *Нийгмийн Халамж: Хувь хүмүүс буюу Өрхөд Олгох Мөнгөн Шилжүүлгийн Тодруулга*-ыг гаргасан.
- ДҮ3. Нийгмийн халамжийн хувьд өр төлбөр үүсэх агшинг тодорхойлох талаархи хэлэлцүүлэг нь нийгмийн халамжийн талаар хэрэглэгчдэд шаардлагатай бүх мэдээллийг санхүүгийн тайлангаар хангаж чадахгүй гэсэн байр сууринд УСНББОУСЗ-ийг хүргэсэн. Үүнийг доорх Үзүүлэн 1-д үлгэрчлэн харуулсан бөгөөд сүүдэрлүүлсэн хүснэгт нь санхүүгийн тайлангаар хангах мэдээллийг илэрхийлнэ. Цаашид аливаа төслийг эхлүүлэхийн өмнө иргэд сонгогчидтой зөвлөлдөх хэрэгтэй гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс УСНББОУСЗ нь дараагийн Зөвлөлдөх Баримт Бичиг, *Нийгмийн Халамж: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилтийн Асуудлууд*-д энэхүү асуудлыг дахин гарган тавьсан бөгөөд Төслийн Хураангуй болох *Санхүүгийн Урт Хугацааны Тогтвортой Байдлын Тайлагнал*-ыг гаргасан. Энэхүү хоёр баримт бичгийг СТ 34-тэй нэг ижил хугацаанд гаргасан.



ДҮ4. 2008 оны 10-р сард УСНББОУСЗ нь дээрх бүх баримт бичигт ирүүлсэн хариултуудыг нягталж шалгасан. Эдгээр хариултыг харгалзан үзсэнээр СТ 34-ийг УСНББОУС болгон боловсруулахгүй байхаар шийдвэрлэсэн. Санхүүгийн тайлан нь нийгмийн халамж үзүүлэх засгийн газрын хөтөлбөрүүдийн санхүүгийн урт хугацааны утга агуулгын талаар хэрэглэгчдэд хангалттай мэдээлэл өгч чадахгүй гэдгийг хариулт ирүүлсэн ихэнх хүмүүс хүлээн зөвшөөрч байгааг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн.<sup>9</sup> Энэхүү байр суурийг харгалзсанаар УСНББОУСЗ нь төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи төслийг (хожим “Төрийн Санхүүгийн Урт Хугацааны Тогтвортой Байдлын Тайлагнал” гэж өөрчлөн нэрлэсэн)

<sup>9</sup> Нийгмийн халамж үзүүлэх үүргээс үүссэн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтэд зориулсан саналын талаархи цаашдын ажлыг *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал*-ын төслийн 2-р үе шатанд шууд бусаар үргэлжлүүлэн явуулсан. Энэхүү үе шатанд элементүүдийг авч үзсэн бөгөөд өр төлбөрийн тодорхойлолт, түүнчлэн татвар ногдуулах бүрэн эрх нь хөрөнгө мөн эсэх гэх мэт бусад холбогдох асуудлуудын боловсруулалтыг хамруулан тусгасан. Энэ ажил нь нийгмийн халамжтай холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих арга хандлагад нөлөөлөх магадлалтай юм. Нийгмийн халамжийн талаархи төслийг УСНББОУСЗ нь дахин сэргээхээр 2003 оны 6 дугаар сарын хурлаараа шийдвэрлэсэн.

## БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ нь 2009 оны 11 дүгээр сард Зөвлөлдөх Баримт Бичиг, *Төрийн Санхүүгийн Урт Хугацааны Тогтвортой Байдлын Тайлагнал*-ыг гаргахад хүргэсэн. Одоогийн практикыг дүрслэн илэрхийлэхдээ, уг Зөвлөлдөх Баримт Бичиг нь төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнаж буй тохиолдлуудыг тусган оруулж, ийм хэр их мэдээлэл толилуулж болох талаар санал гаргасан бөгөөд иргэд сонгогчдын санал бодлыг хүлээн авсан. УСНББОУСЗ нь шаардлагуудыг биш, харин удирдамж боловсруулахыг дэмжиж буйгаа олон хүмүүс илэрхийлсэн боловч уг Зөвлөлдөх Баримт Бичигт хариулт ирүүлсэн ихэнх хүмүүс нь энэхүү төслийг цааш үргэлжлүүлэхийг сайшаан дэмжсэн.

ДҮ5. Зөвлөлдөх Баримт Бичигт ирүүлсэн хариултуудыг харгалзан үзсэнээр УСНББОУСЗ нь СТ 46.СБПУ, *Улсын Секторын Байгууллагын Санхүүгийн Урт Хугацааны Тогтвортой Байдлын Тайлагнал*-ыг боловсруулж, 2011 оны 10 дугаар сард гаргасан. Энэхүү СТ нь төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнаж буй улсын секторын байгууллагуудад зориулсан албан журмын бус удирдамжийг санал болгосон.

ДҮ6. УСНББОУСЗ нь *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал*-ын, ялангуяа уг Үзэл Баримтлалын 2-р бүлгийн талаархи өөрийн төслийн явцад төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээллийг тайлагнах өөрийн үзэл санааг цаашид хөгжүүлсэн. Хэдийгээр санхүүгийн тайлан нь санхүүгийн тайлагналын гол цөм боловч хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахад илүү дэлгэрэнгүй цар хүрээ шаардлагатай гэсэн үзэл бодлыг Бүлэг 2, *Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Зорилтууд ба Хэрэглэгчид*-д тусгасан байдаг. Ийм дэлгэрэнгүй цар хүрээ нь хэтийн санхүүгийн мэдээллийг агуулдаг. Өмнөх шийдвэрийн үр дүн болох үүрэгтэй холбоотой төсөөлсөн зарлагын гүйлгээ ба онцгой бүрэн эрх, татвар ногдуулах бүрэн эрхтэй холбоотой төсөөлсөн орлогын гүйлгээг санхүүгийн байдлын тайланд болон санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй эсвэл зөвхөн хэсэглэн хүлээн зөвшөөрч болно гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Иймээс хариуцлагын болон шийдвэр гаргалтын санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахын тулд байгууллага нь тухайн санхүүгийн тайлан дахь түүний санхүүгийн байдлын талаархи мэдээллийн нэмэлт гүйцээлт болох, ирээдүйн орлогын гүйлгээ ба зарлагын гүйлгээний талаархи мэдээллээр хэрэглэгчдийг хангах хэрэгтэй.

ДҮ7. ДҮ6-р параграфт заасан, төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнах шалтгаан нь зарим байгууллагын хувьд ийм тайлагнал шаардлагатай гэдгийг илэрхийлж болох юм гэж УСНББОУСЗ тэмдэглэсэн. Гэвч НЗСТ дахь төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн тайлагнал нь уг практик дөнгөж хөгжиж буй талбар бөгөөд УСНББОУСЗ нь шинэлэг, уян хатан хандлагыг дэмжихийг хүссэн учраас эрх бүхий тунхаглал гаргахад арай эртэднэ гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Энэхүү хандлага нь СТ 46-д хариулт ирүүлсэн ихэнх хүмүүсийн үзэл бодолтой нийцэж байна. Энэ СБПУ-ийг дагаж мөрдөх нь

сайн практик гэдгийг “Санал Болгосон Практик Удирдамж”-ийн дөрөв дэх догол мөрт дурдсан болохыг УСНББОУСЗ тэмдэглэсэн.

## Цар хүрээ

ДҮ8. СБПУ-ийн цар хүрээг үндэсний болон нийт засгийн газрын нэгтгэсэн түвшнээр хязгаарлах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн тайлагнал нь эдгээр түвшинд онцгой хамааралтай болохыг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн боловч ийм мэдээллийн хэрэглэгчдийн мэдэгдэхүйц эрэлт нь үндэсний дэд түвшинд байж болно гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс үндэсний болон засгийн газрын нийт түвшнээр хязгаарлагдсан явцуу цар хүрээ зохистой биш гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Байгууллага нь төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээллийг тайлагнах хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Зөвлөлийн харгалзан үзсэн хүчин зүйлсийг ДҮ14-ДҮ17-р параграфт авч хэлэлцсэн.

## Тодорхойлолт

*Төсвийн урт хугацааны тогтвортой байдал*

ДҮ9. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байхгүй бөгөөд төсвийн урт хугацааны тогтвортой байдал нь “одоо болон ирээдүйн аль алинд үйлчилгээ үзүүлэх ба санхүүгийн амлалтаа биелүүлэх уг засгийн газрын чадвар боломж” гэсэн түр тодорхойлолт тусган оруулсныг Зөвлөлдөх Баримт Бичигт тэмдэглэсэн. Энэхүү тодорхойлолт нь хангалттай оновчтой биш бөгөөд байгууллагын одоогийн эдийн засгийн байдал тогтвортой эсэх талаар илүү ойлгомжтой үзүүлэлтээр хэрэглэгчдийг хангах тийм тодорхойлолтыг батлан мөрдөх хэрэгтэй гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Ийм хандлага нь дараах зүйлсийг агуулсан байж болно: (а) үйлчилгээ үзүүлэх одоогийн үүргийг татварын одоогийн түвшний хэвээр хадгалалттай холбон уялдуулалт, ба (б) төсөөлсөн өрийн чиглэлд анхаарал хандуулалт. Татвар эсвэл одоогийн үүргийн түвшинг зөвхөн нэмэгдүүлснээр үйлчилгээ үзүүлэх одоогийн үүрэг болон санхүүгийн үүргээ биелүүлж чадах байгууллагыг тогтвортой бус төлөв байдалтай гэж тодорхойлдог. Макро эдийн засагчид нь ийм арай оновчтой хандлагыг хэрэглэх ба “тэсрэлттэй” өрийн чиглэлд илүүтэй анхаарах хандлагатай байдаг. “Тэсрэлттэй” өрийн чиглэл нь өрийн түвшинг ихээхэн нэмэгдүүлэхгүйгээр үйлчилгээний одоогийн түвшин ба эрх олголтын хөтөлбөрүүдээс хүртэх одоогийн өгөөжийг тогтвортой байлгаж чадахгүй гэсэн утга илэрхийлдэг нэр томъёо юм.

ДҮ10. Энэ СБПУ-ийг гаргах үед УСНББОУСЗ нь СТ 46-гийн Зөвлөлдөх Баримт Бичигт ашигласан, төсвийн урт хугацааны тогтвортой байдлын тодорхойлолтыг хэвээр хадгалах ба түүний цар хүрээг засгийн газруудаар хязгаарлах биш, харин ([Улсын Үйлдвэрийн Газрууд]-аас бусад) (2016 оны 4 дүгээр сард УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ыг гаргаснаас хойш ийм дөрвөлжин хаалтанд тусгасан нэр томъёог цаашид ашиглахаа больсон) улсын секторын бүх байгууллагуудад мөрдөж болно гэдгийг

тусгахын тулд цар хүрээг өргөжүүлэхээс бусдаар уг тодорхойлолтыг энэ СБПУ-д цаашид ашиглахаар шийдвэрлэсэн. Энэ дүгнэлтэнд хүрэхдээ УСНББОУСЗ нь (а) үйлчилгээ үзүүлэх ба эрх олгох хөтөлбөрүүдтэй холбоотой үүргийг биелүүлэх, ба (б) санхүүгийн үүргийг биелүүлэх, үндсэндээ өрөө барагдуулах хоёр зорилгын аль алины хувьд засгийн газрын болон улсын секторын байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг онцлон тэмдэглэсэн. Татвар нэмэгдүүлэх боломж нь харгалзах олон асуудлуудаар практикт хязгаарлагддаг байж болно гэдгийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрдөг боловч олон засгийн газрууд нь шинэ татварын эх үүсвэр болох хууль тогтоомжийг батлан гаргах ба одоогийн татварын түшинг өөрчлөх онцгой бүрэн эрхтэй байдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Хэрэв байгууллага нь төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүнүүдэд зохих анхаарал хандуулвал 27-40-р параграфт тайлбарласанчлан, уг байгууллага нь одоогийн үйлчилгээний түвшинг хэвээр хадгалах, эрх олгох хөтөлбөрийн одоогийн болон ирээдүйн өгөөж хүртэгчдийн хувьд үүргээ биелүүлэх, татварын болон бусад эх үүсвэрийн орлогыг нэмэгдүүлэхгүйгээр эсвэл зээлийг нэмэгдүүлэхгүйгээр санхүүгийн үүргээ биелүүлж чадах эсэх талаархи холбогдох мэдээллээр хэрэглэгчдийг хангана гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн.

*Төсөөлөл, прогноз, төсөв*

- ДҮ11. СТ 46-д хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь төсөөлөл, прогноз, төсвийн хоорондох уялдаа холбоог тодорхой болгох хэрэгтэй гэсэн санал гаргасан. Эдгээр нэр томъёоны хувьд нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байхгүй гэдгийг харгалзан үзээд, УСНББОУСЗ нь төсөөллийг тооцоолоход ашиглах мэдээллийн шинж чанаруудыг тодорхой болгох ба зөвхөн эдгээр шинж чанарыг хангасан тооцооллыг энэ СБПУ-ийн цар хүрээнд хамруулна гэдгийг ханган магадлахын тулд төсөөллийн тодорхойлолтыг боловсруулахаар шийдвэрлэсэн.
- ДҮ12. Хэтийн санхүүгийн мэдээлэл нь тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж буюу зохицуулалтын чанд мөрдөлтөнд үндэслэх хэрэгтэй, эсвэл тухайн тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж буюу зохицуулалтын тусгай гажилт нь тохиромжтой байж болох эсэхийг УСНББОУСЗ нь төсөөллийн талаархи өөрийн тодорхойлолтыг боловсруулахдаа харгалзан үзсэн. Илүү хамааралтай мэдээллээр хангахын тулд одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалтаас гажих нь тохиромжтой байх цөөн хязгаарлагдмал тохиолдол байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Иймээс төсөөллийг “тухайн байгууллагын одоогийн бодлогын таамаглал, түүнчлэн ирээдүйн эдийн засгийн болон бусад нөхцөл байдлын талаархи таамаглалд үндэслэн бэлтгэсэн хэтийн санхүүгийн мэдээлэл” гэж тодорхойлдог. Одоогийн бодлогын таамаглал гэдэг нь “тухайн тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль буюу зохицуулалтад үндэслэсэн бөгөөд тодорхойлсон нөхцөл байдлын хувьд зохих гажилтыг агуулсан таамаглалууд” юм. Одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалтаас гажих нь тохиромжтой байх нөхцөл байдлуудыг 43-р параграфт дэлгэрэнгүй дурдсан бөгөөд ДҮ31-34-р параграфт авч хэлэлцсэн.

ДҮ13. Төсөв ба прогноз нь зорьж буй үр дүнгийн талаархи дэлгэрэнгүй мэдээллээр хангах зорилготой байдаг. Харин эсрэгээр, төсөөллүүд нь гүйцэтгэлийн үр дүнгийн талаархи ойролцоо утгаар хангах санаа зорилгогүй байдаг. Төсөв нь тусгайлан заасан тайлант хугацаан дахь уг байгууллагын урьдчилан таамагласан орлого буюу мөнгөн орлого, урьдчилан таамагласан зардал буюу мөнгөн зарлагын төлөвлөгөө юм. Төсөв нь тухайн тайлант үеийн үйлчилгээний үр дүн буюу гарцтай холбоотой байж болно. Хэдийгээр одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалтад тусгагдаагүй байж болох боловч тухайн байгууллагын урьдчилан таамагласан ажиллагаа ба оролцоог агуулсан бөгөөд төсөөллийн тодорхойлолтод дурдсан, хязгаарлагдмал гажилтын хүрээнд байх тийм мэдээллээр прогноз нь хангадаг. Төсөв болон прогнозын зарим мэдээллийг төсөөлөлд мөн ашиглаж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

**Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнах эсэхийг тодорхойлох**

ДҮ14. ДҮ8-р параграфт авч хэлэлцсэнчлэн, энэхүү СБПУ-ийн цар хүрээг засгийн газрын тодорхой түвшнээр хязгаарлах хэрэггүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Гэвч төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээллийн тайлагнал нь бүх байгууллагуудад тохиромжтой биш байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

ДҮ15. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн тайлагнал нь хяналтанд буй бие даасан байгууллагуудын хувьд тохиромжтой эсэхийг Зөвлөлдөх Баримт Бичгээр асууж, санал авсан. Энэхүү урьдчилсан нөхцөл нь дараах төсөөлсөн байр суурьт үндэслэсэн: (а) ийм байгууллагуудын хувьд уг мэдээллийг бэлтгэх өртөг зардал нь хэрэглэгчдэд өгөх өгөөжөөс илүү байх магадлалтай, (б) эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх бие даасан байгууллагууд тусдаа тайлан ба тодруулга бэлтгэх нь хэрэглэгчдийг төөрөгдөлд хүргэж болох юм, (в) татварыг нэмэгдүүлэх хязгаарлагдмал эрхтэй ба нөөцийн хувьд засгийн газрын бусад түвшний байгууллагуудаас хамааралтай байгууллагууд нь өөрөө хянаж чадахгүй буюу маш бага хяналт бүхий татвар ногдуулалтын шийдвэрээс болзошгүй хамаарах тийм төсөөллийг бэлтгэдэг бол энэ нь төөрөгдөлд хүргэж болох юм. Зөвлөлдөх Баримт Бичигт хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь энэ байр суурийг дэмжиж, хяналтанд буй байгууллагуудын төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн хэрэглэгчдийг тогтоож болох тийм тохиолдол байна гэсэн саналыг илэрхийлсэн. Мужийн буюу бүсийн засгийн газрын хяналтанд байдаг орон нутгийн засгийн газрын байгууллагын жишээг иш татсан. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тухайн байгууллага тайлагнах эсэх шалгуур нь энэ төрлийн мэдээллийн хувьд боломжит хэрэглэгч нар оршин байгаа эсэхийг үнэлэх явдал гэж тэдгээр хүмүүс үзэж байсан. УСНББОУСЗ нь ийм шалтгаан үндэслэлүүдийг харгалзаж үзээд эдгээр байр суурийг СБПУ-ийн 12 ба 13-р параграфт тусгасан.

ДҮ16. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн хэрэглэгчдийн оршин байдлын шууд нотолгоо нь бэлэн олдоцтой байхгүй байж болох юм гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. УСНББОУСЗ нь хэрэглэгчдийн оршин байдлыг илэрхийлж болох шинж чанаруудыг төсвийн урт хугацааны тогтвортой байдлын гурван хэмжигдэхүүнээр тодорхойлохыг эрмэлзсэн. Хэрэв байгууллагууд нь дараах нэг буюу хэд хэдэн шинж чанаргүй бол тайлагналын өртөг зардлыг зөвтгөн батлах хангалттай тооны хэрэглэгчид байх эсэх талаар УСНББОУСЗ нь түдгэлзсэн байр суурьтай байсан:

- (а) Татварын ба/буюу бусад мэдэгдэхүйц орлогыг бий болгох бүрэн эрх;
- (б) Мэдэгдэхүйц хэмжээний өр үүсгэх бүрэн эрх; эсвэл
- (в) Үйлчилгээний шинж төрөл, түвшин, үзүүлэх арга, үүн дотроо шинэ үйлчилгээний танилцуулгыг тодорхойлох бүрэн эрх ба чадавхи.

ДҮ17. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн тайлагнал нь нийт засгийн газрын түвшин, нэгтгэсэн үндэсний түвшин, түүнчлэн өөрийн нийт орлогын мэдэгдэхүйц хэсгийг бүрдүүлэх боломжийг түүнд олгох татвар нэмэгдүүлэх бүрэн эрх бүхий бүсийн, хөдөөгийн, мужийн гэх мэт үндэсний дэд түвшний гол байгууллагууд болон орон нутгийн (жишээлбэл; хотын) засаг захиргааны томоохон байгууллагуудад хамааралтай байх магадлалтай гэж УСНББОУСЗ үздэг. Яагаад гэвэл, тэдгээр байгууллага нь ихэвчлэн татвар нэмэгдүүлэх бүрэн эрхгүй бөгөөд тэдний зарлагыг төсвийн хуваарилалтаар дамжуулан хянадаг ба тэд өр үүсгэх бүрэн эрхгүй байдаг.

### **Ирээдүйн орлогын болон зарлагын гүйлгээний төсөөллийг толилуулах**

ДҮ18. Зөвлөлдөх Баримт Бичигт төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийг тайлагнах гурван загварыг авч үзсэн бөгөөд (а) төсөөллийн дэлгэрэнгүй мэдээллээр хангах нэмэлт тайлан бэлтгэх, ба (б) хүүрнэсэн тайлагнал байдлаар хураангуйлсан төсөөлөл тохиромжтой гэдгийг санал болгосон. Тайлагналын эдгээр хандлагууд нь бие биенийгээ үгүйсгэхгүй гэдгийг Зөвлөлдөх Баримт Бичигт тэмдэглэсэн боловч төсөөллийг зөвхөн тайлан хэлбэрээр харуулснаар төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээллийг тайлагнах нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахад хангалтгүй бөгөөд толилуулгын өөр бусад арга ашиглахыг УСНББОУСЗ онцлон тэмдэглэх хэрэгтэй гэдгийг хариулт ирүүлсэн зарим хүмүүс санал болгосон. УСНББОУСЗ нь энэхүү байр суурийг харгалзан үзээд түүнийг СБПУ-ийн 17-р параграфт тусгахыг зөвшөөрсөн.

ДҮ19. Засгийн газрын тодорхой түвшний байгууллагуудын хувьд төсөөллийн хугацааны хамрах хүрээг санал болгох хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. Улсын секторын тодорхой төрлийн байгууллагад зориулсан хугацааны стандарт хамрах хүрээ нь зэрэгцүүлэгдэх байдлыг сайжруулж болох юм гэсэн байр суурийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.



Ийм бенчмарк тогтоолт нь хэт зааварчилсан шинжтэй болох ба практик боломжгүй гэж УСНББОУСЗ үзсэн. Энэ СБПУ-ийн цар хүрээ нь өргөн хүрээний янз бүрийн байгууллагуудын, үүн дотроо бие даан тайлагнаж буй байгууллагуудын хувьд хугацааны ийм стандарт хамрах хүрээг тодорхойлох шаардлагатай болгодог.<sup>10</sup> Түүнчлэн, засгийн нэг ижил түвшний байгууллагуудын төсвийн бие даасан байдал нь улс орон бүрд эрс өөр байж болно. Гэвч байгууллагууд нь тухайн хугацааны хамрах хүрээг сонгосон шалтгаанаа тайлбарлах нь сайн практик гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Санхүүжилтийн хувьд бусад байгууллагуудаас уг байгууллагын хамааралтай байдлын хэмжээ нь хугацааны хамрах хүрээнд нөлөө үзүүлнэ, хамааралтай байдлын түвшин өндөр байхын хэрээр хугацааны хамрах хүрээ богино байх магадлалтай гэж УСНББОУСЗ үзсэн.

ДҮ20. Гол хөтөлбөр ба үйл ажиллагааны 75 жилийн төсөөллийг харуулсан хүснэгтэн тайлангийн үлгэрчилсэн жишээг Зөвлөлдөх Баримт Бичигт тусган оруулсан. Хугацааны хамрах хүрээний эцэс дэх төлөв байдалд анхаарал хандуулах нь уг тайлангийн өдөр ба тухайн хугацааны хамрах хүрээний эцсийн хоорондох үйл явдлуудыг бүрхэгдүүлж болох юм гэсэн зарим хүмүүсийн үзэл бодлыг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь уг үзэл бодлыг хүлээн зөвшөөрсөн ба төсөөллийг толилуулахдаа шалгах боломжтой байх, үнэн зөв илэрхийлэх, хамааралтай байх гэсэн чанарын шинжүүдийн тэнцвэрийг хангах шаардлагын талаархи заавар удирдамжийг энэхүү СБПУ-ийн 25-р параграфт тусган оруулсан.

#### **Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүнүүдийг авч үзэх**

ДҮ21. Мэдээллийн тодруулгын хувьд уян хатан хүрээ тогтоох нь мэдээллээ хүргэн танилцуулах арга замыг зохион байгуулах, түүнчлэн уг мэдээлэл нь тухайн байгууллагын төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн үнэн зөв илэрхийлэл гэдгийг ханган магадлахад байгууллагуудад тусалж болох юм гэж УСНББОУСЗ үзсэн.

ДҮ22. Төсвийн урт хугацааны тогтвортой байдлын дараах гурван хэмжигдэхүүнийг СТ 46-д тусган оруулсан:

- Төсвийн чадавхи;
- Үйлчилгээний чадавхи; ба
- Эмзэг байдал.

ДҮ23. Эмзэг байдлын тайлбар тодорхойлолтыг Канадын Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Зөвлөл (КУСНББЗ)-өөс гаргасан, Санал Болгосон Практик Тунхаглал 4 (СБПТ-4), *Санхүүгийн Байдлын Үзүүлэлтүүд*-д тусгасан, эмзэг байдлын тодорхойлолтоос авсан. СБПТ-4-д заасан тодорхойлолтоор эмзэг байдал нь “засгийн газар нь өөрийн хяналт буюу нөлөөллөөс ангид санхүүжилтийн эх үүсвэрээс хамааралтай байх, эсвэл олон нийтийн өмнө хүлээсэн үйлчилгээний амлалт болон

---

<sup>10</sup> Жишээлбэл; ийм байгууллагууд нь цэвэр, бохир усыг хариуцсан сургуулийн зөвлөл буюу хороотой байж болно.

зээлдүүлэгчид, ажиллагчид ба бусад талуудын өмнө хүлээсэн санхүүгийн амлалтын аль алины хувьд өөрийн одоогийн санхүүгийн үүргийг биелүүлэх түүний чадвар боломжийг бууруулж болох эрсдэлд өртөх хэмжээ” юм. Энэхүү ойлголтын өөр хувилбар нь татвар ногдуулалтын хувьд хязгаарлагдмал бүрэн эрхтэй, иймээс засгийн газрын өөр түвшний бусад байгууллагуудын гаргасан ба өөрөө хяналт тавьдаггүй буюу маш бага хяналт бүхий шийдвэрийн улмаас эрсдэл хүлээдэг үндэсний дэд түвшний байгууллагуудад ихээхэн ач холбогдолтой гэж УСНББОУСЗ үзсэн.

ДҮ24. СТ 46-д тусгасан өөр хоёр хэмжигдэхүүний тайлбар тодорхойлолтыг АНУ-ын Засгийн Газрын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөл (ЗГНББСЗ)<sup>11</sup>-өөс гаргасан “төсвийн чадавхи” ба “үйлчилгээний чадавхи” гэсэн тодорхойлолтуудаас авсан. ЗГНББСЗ нь төсвийн чадавхийг “барагдуулах хугацаа болох үед өөрийн санхүүгийн үүргийг тасралтгүй байдлаар биелүүлэх уг засгийн газрын чадвар боломж ба бэлэн байдал” гэж, харин үйлчилгээний чадавхийг “үйлчилгээ үзүүлэх өөрийн амлалтыг тасралтгүй байдлаар биелүүлэх уг засгийн газрын чадвар боломж ба бэлэн байдал” гэж тодорхойлсон.

ДҮ25. СТ 46 дахь эмзэг байдлын ойлголт нь хэт явцуу эсэх, мөн эмзэг байдал нь байгууллагын санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлын шинжилгээний хувьд илүү голлох хүчин зүйл эсэхийг УСНББОУСЗ нь уг СТ-д үндэслэн энэхүү СБПУ-ийг боловсруулахдаа харгалзан үзсэн. Эмзэг байдал нь бүх гурван хэмжигдэхүүний шинж төлөв гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс УСНББОУСЗ нь (а) эмзэг байдал гэсэн ойлголт нь төсвийн урт хугацааны тогтвортой байдлын хэмжигдэхүүн бүрд хэрхэн нөлөөлөхийг тайлбарлах, ба (б) эмзэг байдлын тайлбар тодорхойлолт нь орлогын өөрчлөлттэй холбоотой учраас эмзэг байдлын хэмжигдэхүүний нэрийг орлогын хэмжигдэхүүн гэж өөрчлөхөөр шийдвэрлэсэн.

ДҮ26. Төсвийн чадавхийн тайлбар тодорхойлолт нь санхүүгийн амлалтаа биелүүлэх уг байгууллагын чадвар боломжтой, өөрөөр хэлбэл өрийг хэвийн хэмжээнд байлгах ба барагдуулах түүний чадвар боломжтой холбоотой, харин “төсөв”-ийн толь бичгийн тодорхойлолт нь орлогыг<sup>12</sup> тусган агуулсан байдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь уг тайлбар тодорхойлолтыг илүү нягт тусгахын тулд энэхүү хэмжигдэхүүний нэрийг өрийн хэмжигдэхүүн болгож өөрчлөх хэрэгтэй гэж шийдвэрлэсэн. Хоёр хэмжигдэхүүний нэрийг өөрчилснөөр энэхүү гурван хэмжигдэхүүний нэршлийг харилцан уялдаатай болгохын тулд үйлчилгээний чадавхи гэсэн хэмжигдэхүүний нэрийг өөрчлөх

---

<sup>11</sup> *Эдийн Засгийн Байдлын Тайлагналтай холбоотой Гол Асуудлуудын талаархи Засгийн Газрын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөлийн Урьдчилсан Байр Суурь: Санхүүгийн Төсөөлөл* (Засгийн Газрын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөл: Норвалк, СТ, АНУ, 2011 оны 11-р сар).

<sup>12</sup> Төсвийн тодорхойлолт нь “татвар, улсын орлого, улсын өрийн тодорхойлолт буюу түүнтэй холбоотой” байдаг (Вебстерийн Коллежийн Шинэ Тайлбар Толь, 9 дэх хэвлэл, 1984 он).

шаардлагатай болсон. Эдгээр хэмжигдэхүүнүүд нь хоорондоо харилцан холбоотой гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

- ДҮ27. КУСНББЗ ба ЗГНББСЗ-өөс баримталдаг арга хандлага нь Аллен Шик<sup>13</sup>-ийн боловсруулсан тогтвортой байдлын “хэмжигдэхүүнүүд”-тэй ижил төсөөтэй гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн бөгөөд Зөвлөлдөх Баримт Бичигт авч хэлэлцсэн.
- ДҮ28. Шикийн авч хэлэлцсэн хэмжигдэхүүнүүдийн нэг нь “эдийн засгийн өсөлт” юм. Эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч үзүүлэлтүүд нь нарийн цогц бөгөөд уг тайлагнагч байгууллагын хяналтаас ангид байдаг тул эдийн засгийн өсөлт гэсэн хэмжигдэхүүнийг шууд оруулах нь тохиромжгүй гэж УСНББОУСЗ үзсэн. Гэвч эдийн засгийн өсөлтийн талаархи таамаглалууд нь төсөөлөл боловруулахад чухал ач холбогдолтой бөгөөд мэдрэмжийн шинжилгээнд жинтэй байр суурьтай байх магадлалтай юм.

### Зарчим ба арга зүй

- ДҮ29. Төсөөллийн үр дүнгийн гол цөм болох төсвийн урт хугацааны тогтвортой байдлын мэдээллийн тайлагналд хөтөлбөр ба үйл ажиллагаануудыг тусган оруулахад баримтлах зарчим болон арга зүйг Зөвлөлдөх Баримт Бичигт авч хэлэлцсэн. Авч үзсэн талбаруудад дараах зүйлсийг хамруулсан: төсөөлөл нь одоогийн эсвэл ирээдүйн бодлогод үндэслэх эсэх, орлогын гүйлгээний хандлага, насжилттай холбоотой болон насжилттай холбоогүй хөтөлбөрүүдэд баримтлах хандлага, мэдрэмжийн шинжилгээний арга хандлага. Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал чанарын шинжийг хангахын тулд УСНББОУСЗ нь сайн практикын талаар тодорхой зөвлөмж гаргах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн.
- ДҮ30. (а) Улсын секторын бүх байгууллагууд болон практикыг хамарсан энэхүү СБПУ-ийн цар хүрээ нь засгийн газрын нэг түвшний хувьд тохиромжтой боловч улсын секторын өөр нэг талбарын хувьд тохиромжгүй байж болно, (б) төсвийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи мэдээллийн тайлагнал нь олон улс орны хувьд санхүүгийн удирдлагын гол шинж болж байгаа боловч энэ нь хөгжлийн эхлэлийн шатандаа байгаа, ба (в) тухайн талбартаа мэргэшсэн бусад мэргэжлийн бүлгүүдийн үүргийг булаан авах нь УСНББОУСЗ-ийн санаа зорилго биш учраас УСНББОУСЗ нь сайн практикын талаар тодорхой зөвлөмж гаргах нь тохиромжгүй гэж үзсэн. Зарим тохиолдолд УСНББОУСЗ нь хамгийн өндөр түвшний арга хандлагын талаар өөрийн байр суурийг илэрхийлэх нь тохиромжтой гэж үзсэн. Жишээлбэл; төсөөлөл нь одоогийн бодлогын таамаглалуудад үндэслэсэн бөгөөд орлогын гүйлгээ, түүнчлэн зарлагын гүйлгээний аль алиныг агуулсан тохиолдолд хамгийн их ач холбогдолтой байх магадлалтай гэсэн байр суурийг УСНББОУСЗ баримталдаг. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага нь үндэсний түвшинд төсөөллийг жил

---

<sup>13</sup> Аллен Шик, *Төсвийн Тогтвортой Бодлого: Ойлголт ухаагдахуун ба Арга хандлагууд* (ЭЗХАХБ: Парис, 2005 он).

бүр шинэчлэн баяжуулж байх хэрэгтэй гэж зөвлөмж болгосныг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн.

*Одоогийн бодлогын таамаглал*

- ДҮ31. (а) одоогийн бодлого ба хуулийн үүрэг хоорондоо зөрчилтэй, ба (б) бодлого нь “өндөрлөх” заалттай тохиолдолд байгууллага нь өөрийн төсөөллийг тооцоолохдоо одоогийн бодлого ашиглахаас татгалзаж болно гэдгийг СТ 46-гийн 40-42-р параграфт тайлбарласан.
- ДҮ32. Одоогийн бодлого нь тохиромжтой үед зохих гажилтыг агуулсан одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалт гэсэн утгатай болохыг тодорхойлох үүднээс УСНББОУСЗ нь “одоогийн бодлогын таамаглал” нэр томъёог хэрэглэж нэвтрүүлсэн. Бие даасан байдлаар төсөөлдөг орлогын буюу зарлагын гүйлгээний хувьд одоогийн бодлогын таамаглалыг уг төсөөллийн нийт хугацаанд хэрэглэнэ. Гажилт тохиромжтой байж болох тохиолдлуудын жишээг энэ СБПУ-ийн 44-46-р параграфт тусгасан. Одоогийн хууль тогтоомж буюу зохицуулалтын аливаа гажилтыг түүний шалтгааны хамт тодруулахаар энэ СБПУ-ийн 58(д) параграфт зөвлөмж болгосныг УСНББОУСЗ тэмдэглэсэн.
- ДҮ33. Төсвийн дарамт гэх мэт асуудлуудыг авч үзэхийн тулд одоогийн бодлогын ойлголт ухагдахуун нь СТ 46-д тусгаснаас илүү өргөн хүрээтэй байвал зохино гэсэн саналыг СТ 46-д хариулт ирүүлсэн хүмүүс илэрхийлсэн. Төсвийн дарамт гэдэг нь хувь хүний орлого өсөхийн хэрээр өсөн нэмэгдэх илүү өндөр хувь хэмжээгээр татвар ногдуулдаг учраас татварын орлогын гүйлгээ нь түүнийг ногдуулж буй орлогоос илүү хурдацтайгаар өсөх нөхцөл байдлыг илэрхийлдэг. Хувь хүний татварын хувь хэмжээ ба босго шалгуурыг цаг хугацааны явцад тохируулдаггүй бөгөөд засгийн газар нь татварын босгыг үечлэн нэмсэнээр үүнийг ихэвчлэн авч үздэг бол төсвийн дарамт үүсдэг.
- ДҮ34. Одоогийн бодлогын таамаглалуудыг хүн ам зүйн болон эдийн засгийн таамаглалуудад, үүн дотроо инфляцийн таамаглалд мөрдөх боломж олгосон учраас төсвийн дарамтын асуудлыг энэ СБПУ-ийн 47-р параграфт харгалзан тусгасан гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Татвар гэх мэт гүйлгээг загварчилдаг тохиолдолд энэ нь ДНБ гэх мэт хувьсагчийн хувийн жинд үндэслэдэг, эсвэл хүн ам зүйн болон эдийн засгийн таамаглалуудад харгалзсан уг өөрчлөгдөж буй нөхцөл байдалд одоогийн бодлогын таамаглалуудын мөрдөлтийг тусгаж болох юм.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд СБПУ 1-д хийсэн хянан засварлалт**

- ДҮ35. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь бүх УСНББОУС дахь хэллэгт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

## БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

- (a) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **СБПУ 2—САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ШИНЖИЛГЭЭ**

### **СБПУ-ийн түүх**

СБПУ 2, Санхүүгийн Тайлангийн Хэлэлцүүлэг ба Шинжилгээ-г 2013 оны 7-р сард гаргасан.

Үүнээс хойш, СБПУ 2-т дараах УСНББОУС-уудаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал* (2016 оны 4 дүгээр сард гаргасан)

### **СБПУ 2-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт**

<b>Өөрчлөгдсөн параграф</b>	<b>Хэрхэн өөрчилсөн</b>	<b>Юугаар өөрчилсөн</b>
6	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ШИНЖИЛГЭЭ АГУУЛГА

---

	Параграф
Зорилт	1
Төлөв байдал ба цар хүрээ	2-8
Тодорхойлолт	9
Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг тодорхойлох	10-12
Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг толилуулах	13-14
Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний агуулга	15-31
Байгууллагын үйл ажиллагааны болон орчны тойм	19
Байгууллагын зорилт ба стратегийн талаархи мэдээлэл	20-21
Байгууллагын санхүүгийн тайлангийн шинжилгээ	22-26
Эрсдэл ба тодорхойгүй байдал	27-31
Хавсралт А: УСНББОУС-уудад тодорхойлсон, энэ СБПУ-ийн нэр томъёо	
Дүгнэлтийн үндэслэл	

---

## Зорилт

1. Энэхүү Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ) нь санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг бэлтгэж, толилуулах заавар удирдамжаар хангана. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (“санхүүгийн тайлан”)-д толилуулсан санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг ойлгоход хэрэглэгчдэд тусална.

## Төлөв байдал ба цар хүрээ

2. Энэхүү СБПУ-ийн дагуу хийгдэх мэдээллийн тайлагнал нь сайн практикыг илэрхийлнэ. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг бэлтгэж, толилуулж буй байгууллага нь энэ СБПУ-ийг дагаж мөрдөхийг сайшаан дэмжинэ. Байгууллага нь өөрийн санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-д нийцсэн гэж мэдэгдэхийн тулд энэхүү СБПУ-ийг даган мөрдсөн байхыг шаардахгүй.
3. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг наад зах нь жил бүр толилуулах бөгөөд тухайн санхүүгийн тайланд хамаарах тайлант үетэй ижил тайлант үеийг ашиглах хэрэгтэй.
4. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний тайлагналын хил хязгаар нь тухайн санхүүгийн тайланд ашигласан хил хязгаартай ижил байвал зохино.
5. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг тухайн санхүүгийн тайлантай хамт гаргах хэрэгтэй.
6. [Хассан]
7. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь энэ СБПУ-ийн бүх шаардлагуудтай нийцсэн байхаас бусад тохиолдолд түүнийг энэ СБПУ-тай нийцсэн гэж тодорхойлж болохгүй.
8. Зарим улс орны хувьд, санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний бэлтгэлт болон толилуулга нь хууль тогтоомж буюу зохицуулалтын шаардлага байдаг эсвэл гаднаас тавьсан бусад зохицуулалтаар үүнийг шаарддаг. Энэхүү СБПУ-ийн даган мөрдөлтөнд ийм шаардлагуудын үзүүлэх үр нөлөөний талаархи мэдээллийг байгууллагууд нь тодруулахыг сайшаан дэмжинэ.

## Тодорхойлолт

9. Энэ СБПУ-д дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ гэдэг нь байгууллагын санхүүгийн тайланд толилуулсан томоохон зүйлс, ажил гүйлгээ, үйл явдлын болон тэдгээр нөлөөлсөн хүчин зүйлсийн тайлбар юм.



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ШИНЖИЛГЭЭ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсон утгаар энэ СБПУ-д хэрэглэсэн бөгөөд Хавсралт А-д харуулсан.

### **Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг тодорхойлох**

10. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг маш ойлгомжтой тодорхойлж, тухайн санхүүгийн тайлан болон бусад мэдээллээс ялган зааглах хэрэгтэй.
11. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний тусдаа тодруулга нь дараах зүйлсийг ялган тогтоох боломжийг хэрэглэгчдэд олгодог:
  - (а) УСНББОУС-уудын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэж, толилуулсан санхүүгийн тайлан;
  - (б) Энэхүү СБПУ-ийн дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ; ба
  - (в) Хэрэглэгчдэд ач холбогдолтой байж болох боловч УСНББОУС-уудын шаардлагууд буюу СБПУ-уудын зөвлөмжид захирагддаггүй (гэвч зарим СБПУ-ийн заавар удирдамжид захирагддаг байж болно), жилийн тайлан илтгэлд эсвэл бусад баримт бичигт толилуулсан бусад мэдээлэл.
12. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь өөрийн хамаарах санхүүгийн тайланг тодорхойлсон байвал зохино.

### **Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг толилуулах**

13. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь тухайн байгууллагын өөрийн зүгээс түүний үйл ажиллагааны талаар гүнзгий ойлголт олж авах боломжийг хэрэглэгчдэд олгосноор тэдний хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой мэдээллээр хэрэглэгчдийг хангадаг. Энэ нь байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд нөлөөлөх томоохон зүйлс, ажил гүйлгээ, үйл явдлын талаархи уг байгууллагын тайлбарыг тусгах боломжийг бас олгодог. Иймээс санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь тухайн санхүүгийн тайлан дахь мэдээллийн гүйцээлт болдог.
14. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний мэдээлэл нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (НЗСТ)-д тусгасан мэдээллийн хязгаарлалтуудыг харгалзсанаар тухайн санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг хангадаг байвал зохино<sup>1</sup>.

---

<sup>1</sup> Санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх шинжүүд юм. Мэдээллийн хязгаарлалтууд нь материаллаг байдал, өртөг-өгөөжийн тэнцвэр, чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр юм. Дэлгэрэнгүй

## Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний агуулга

15. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний агуулга нь тухайн санхүүгийн тайлан ба суурь зүйлс, ажил гүйлгээ, үйл явдал, түүнчлэн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилттэй холбоотой таамаглалууд гэх мэт холбогдох таамаглалуудтай нийцсэн байвал зохино.
16. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь тухайн санхүүгийн тайлан дахь мэдээллийг зүгээр давтан илэрхийлэхгүй, харин дараах зүйлсийг агуулсан байвал зохино:
  - (а) Байгууллагын үйл ажиллагаа болон түүний үйл ажиллагаа явуулдаг орчны тойм;
  - (б) Байгууллагын зорилт ба стратегийн талаархи мэдээлэл;
  - (в) Байгууллагын санхүүгийн тайлангийн шинжилгээ, үүн дотроо уг байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний мэдэгдэхүйц өөрчлөлт ба хандлага; ба
  - (г) Байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд нөлөөлөх уг байгууллагын үндсэн эрсдэл ба тодорхойгүй байдлын талаархи тайлбар тодорхойлолт, түүнчлэн хамгийн сүүлийн тайлангийн өдрөөс хойш тэдгээр эрсдэл ба тодорхойгүй байдалд гарсан өөрчлөлтийн тайлбар, тэдгээр эрсдэл ба тодорхойгүй байдлыг даван туулах буюу бууруулах түүний стратеги.
17. Байгууллагын санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний хэлбэр болон тусгайлсан агуулга нь уг байгууллагын шинж төрөл, түүний үйл ажиллагаагаа явуулдаг зохицуулалтын орчныг тусгасан байвал зохино.
18. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь тухайн санхүүгийн тайланд бас тусгагддаг мэдээллийг агуулдаг тохиолдолд уг санхүүгийн тайлан дахь мэдээллийг зүгээр давтан илэрхийлэхгүй, харин тэдгээр зүйлс, ажил гүйлгээ, үйл явдлууд нь тэрхүү байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд хэрхэн нөлөөлөхийг шинжилж, тайлбарласан байх хэрэгтэй. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь тохиромжтой тохиолдолд мэдээллийн давхардлаас зайлсхийхийн тулд уг санхүүгийн тайланд хийсэн харилцан лавлагааг агуулсан байвал зохино.

### Байгууллагын үйл ажиллагааны болон орчны тойм

19. Байгууллагын тойм мэдээ нь тухайн байгууллагын санхүүгийн тайланд түүний үйл ажиллагаа, түүнчлэн үйл ажиллагаа явуулдаг орчин хэрхэн нөлөөлдөгийг ойлгоход хэрэглэгчдэд тусалдаг. Энэ мэдээлэл нь тухайн байгууллагын санхүүгийн тайланг ойлгоход хэрэглэгчдэд тусална. Байгууллагын үйл ажиллагааны талаар уг санхүүгийн тайлангийн

---

мэдээллийг *Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын 3-р бүлгээс үзнэ үү.*

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ШИНЖИЛГЭЭ

хэлэлцүүлэг ба шинжилгээнд тусгасан мэдээлэл нь дараах зүйлстэй холбоотой одоогийн мэдээлэл болон өмнөх үеэс хойш орсон өөрчлөлтийг агуулсан байж болно:

- (а) Байгууллагын эрхэм зорилго ба хэтийн зорилго;
- (б) Байгууллагын засаглал (жишээлбэл; хууль тогтоомжийн болон зохицуулалтын бүтэц, удирдлагын бүтэц);
- (в) Байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд (жишээлбэл; санхүүжилтийн арга хэмжээнд) мэдэгдэхүйц нөлөөлж болох харилцаа холбоонд голлон анхаарсан уг байгууллагын бусад байгууллагуудтай холбогдох харилцаа;
- (г) Байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд мэдэгдэхүйц нөлөөтэй буюу нөлөөтэй байж болох тухайн байгууллагад тусгайлан хамаарах хуулийн, зохицуулалтын, нийгмийн, улс төрийн, макро-эдийн засгийн орчны гадаад хандлага, үйл явдал ба хөгжил өөрчлөлт (жишээлбэл; ажил эрхлэлт, татварын суурь, хүүний түвшинд олон улсын зах зээл дэх үйл явдлын үзүүлэх үр нөлөө); ба
- (д) Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, үүн дотроо үйлчилгээ үзүүлэх аргууд (жишээлбэл; аутсорсинг, үйлчилгээний концесс хэлцэл) болон тэдгээрт гарсан мэдэгдэхүйц өөрчлөлтүүд.

### **Байгууллагын зорилт ба стратегийн талаархи мэдээлэл**

- 20. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь байгууллагын тэргүүн ач холбогдолтой зүйлсийг ойлгох, тэдгээр зорилт ба стратегид хүрэхийн тулд удирдан чиглүүлэх нөөцүүдийг тодорхойлох боломжийг тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох тийм байдлаар уг байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээтэй холбоотой зорилт болон стратегийг авч хэлэлцсэн байвал зохино. Жишээлбэл; ийм зорилт ба стратегид нь ашиг/алдагдлын удирдлага, өр ба нөөцийн түвшний удирдлага хамаарч болох юм. Байгууллагын зорилтуудын хэрэгжилтийг хэрхэн хэмжих ба явц өрнөлийг ямар хугацаагаар хэмжих эсэхийг санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээнд тайлбарлах хэрэгтэй.
- 21. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь байгууллагын зорилт ба стратегид өмнөх тайлант үе буюу үеүдээс хойш орсон мэдэгдэхүйц өөрчлөлтүүдийг авч хэлэлцвэл зохино.

### **Байгууллагын санхүүгийн тайлангийн шинжилгээ**

- 22. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд орсон мэдэгдэхүйц өөрчлөлт болон хандлагын шинжилгээг тусгасан байвал зохино. Хандлагын шинжилгээ нь байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний, түүнчлэн цаг хугацааны явцад санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд орсон

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ШИНЖИЛГЭЭ

өөрчлөлтийн талаар илүү сайн ойлголттой болоход чухал ач холбогдолтой бөгөөд мэдэгдэхүйц нөлөөтэй санхүүгийн тайлангийн тэдгээр зүйлсийг агуулсан байдаг.

23. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь тухайн санхүүгийн тайланд толилуулсан мэдээллийг зүгээр давтан илэрхийлэхгүй, харин санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд нөлөөлсөн томоохон зүйлс, ажил гүйлгээ, үйл явдлыг тайлбарлан тодорхойлох хэрэгтэй. Томоохон зүйлс, ажил гүйлгээ, үйл явдлыг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийх шаардлагатай юм.
24. Санхүүгийн тайлангаас авсан мэдээллийг тэрхүү санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээнд тусгахын тулд тохируулдаг бол уг тохируулгын шинж төрөл болон шалтгааны хамтаар энэ тухай тодруулга хийвэл зохино. Санхүүгийн үр дүнгийн хэмжүүрүүдийг санхүүгийн тайлангаас гаргадаг бол УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн уг санхүүгийн тайланд толилуулсан хэмжүүртэй тэдгээр хэмжүүрийг тохируулах хэрэгтэй.
25. Тухайн тайлант үеийн санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг ойлгоход хамааралтай тохиолдолд уг санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээнд толилуулсан дүнгүүдийн хувьд зэрэгцүүлэгдэх мэдээллийг тодруулах хэрэгтэй.
26. Байгууллага нь өөрийн батлагдсан төсөв(үүд)-ийг олон нийтэд нээлттэй танилцуулах сонголт хийсэн эсвэл ийм шаардлагатай тохиолдолд тухайн санхүүгийн тайланд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг тусгахыг УСНББОУС 24, *Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга*-аар шаардсан байдаг. Мөн УСНББОУС 24 нь төсөвлөсөн дүн ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох материаллаг зөрүүг тайлбарлахыг шаарддаг бөгөөд ийм мэдээллийг байгууллага нь тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд, эсвэл олон нийтэд нээлттэй бусад тайланд тодруулахыг УСНББОУС 24-өөр зөвшөөрсөн байдаг. Байгууллага нь энэхүү мэдээллийг өөрийн санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээнд тусган оруулах сонголт хийсэн тохиолдолд тэдгээр тодруулгын хувьд УСНББОУС 24-ийн заавар удирдамжийг мөрдөх хэрэгтэй.

### **Эрсдэл ба тодорхойгүй байдал**

27. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд нөлөөлөх түүний үндсэн эрсдэл болон тодорхойгүй байдлыг авч хэлэлцэж, уг байгууллагын зорилт, стратегитэй энэ нь ямар холбоотой талаархи тайлбарыг тусгасан байвал зохино. Энэхүү мэдээлэл нь тухайн тайлант үед, түүнчлэн хүлээгдэж буй үр дүнд эдгээр эрсдлийн үзүүлэх нөлөөллийг (жишээлбэл; санхүүгийн тайланд тодруулсан болзошгүй өр төлбөр эсвэл эрсдлийг бууруулах гадаад валютын хейж ашиглалтыг) үнэлэхэд хэрэглэгчдэд тусална.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ШИНЖИЛГЭЭ

28. Үндсэн эрсдэл ба тодорхойгүй байдал нь гадаад эсвэл дотоод эрсдэл байж болно; эдгээр эрсдэл болон тодорхойгүй байдлын аливаа тайлбар тодруулга нь сөрөг үр дагавар ба сайн боломжийн аль алиныг тусгасан байвал зохино.
29. Өөрийн эрсдэл ба тодорхойгүй байдлыг байгууллага хэрхэн удирддаг талаархи хэлэлцүүлэг нь түүний санхүүгийн тайлангийн зүйлсэд шууд нөлөөлөх уг байгууллагын эрсдэлд өртөлтийн хувьд үнэн зөв илэрхийллийг олж авахад хэрэглэгчдэд тусалдаг бөгөөд энэ нь тэрхүү байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэлэх боломж олгодог. Ийм тодруулга нь зарим эрсдлийн хувьд “өөрийгөө даатгах” эсвэл даатгалаар дамжуулан шилжүүлэх буюу хуваалцах замаар эрсдлийг бууруулах уг байгууллагын шийдвэрийг тусган агуулсан байж болно.
30. Эдгээр эрсдэл ба тодорхойгүй байдлын хэлэлцүүлэг нь тодорхой бүс нутаг буюу салбарт олгосон мэдэгдэхүйц хэмжээний зээл, эсвэл орлогын тодорхой эх үүсвэрээс хамааралтай байдал гэх мэт эрсдлийн төвлөрөлт буюу эмзэг байдлын талаархи холбогдох мэдээллээр хэрэглэгчдийг хангадаг.
31. Санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд нөлөөлөх эрсдэл ба тодорхойгүй байдал нь санхүүгийн тайланд өргөн хүрээний нөлөөлөлтэй байж болно. Иймээс эдгээр эрсдэл ба тодорхойгүй байдалтай холбоотой мэдээллийг тус тусад нь, эсвэл санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний хамааралтай хэсгүүдэд тайлагнаж болно.

## Хавсралт А

### УСНББОУС-уудад тодорхойлсон, энэ СБПУ-ийн нэр томъёо

Нэр томъёо	Тодорхойлолт
<b>Батлагдсан төсөв</b>	Хууль, төсвийн хуваарилалтын мэдэгдэл, засгийн газрын тогтоол болон тухайн төсвийн хугацааны урьдчилан төсөөлсөн орлого буюу мөнгөн орлоготой холбоотой бусад шийдвэрээр үүсэх зарлагын эрх юм.

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь СБПУ 2-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Оршил

- ДҮ1. “Хүүрнэсэн тайлагнал”-ыг авч үзэх төслийг УСНББОУСЗ нь 2008 оны 3 дугаар сард баталсан. УСНББОУСЗ-ийн *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* (Онолын Үзэл Баримтлал)-д тусгасан, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийг хамрах илүү өргөн хүрээтэй тайлангийн төрлүүд бус, харин УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Топилуулга*-д заасан, байгууллагын нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (“санхүүгийн тайлан”)-д тусгайлан хамаарах хэлэлцүүлэг ба шинжилгээгээр хангах зөвхөн тэдгээр тайланг уг төслийн цар хүрээнд хамруулна гэдгийг УСНББОУСЗ нь энэ СБПУ-ийг боловсруулах үедээ тодруулж өгсөн. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн хариуцлагын болон шийдвэр гаргалтын хувьд хэрэгцээт мэдээллээр хангадаг тул санхүүгийн тайлантай шууд холбоотой хүүрнэсэн мэдээлэл нь чухал ач холбогдолтой гэж УСНББОУСЗ үзсэн.
- ДҮ2. Энэхүү төслийг хэрэгжүүлэхдээ, УСНББОУСЗ нь *Удирдлагын Тайлбар Дүгнэлт*-тэй нийцсэн заавар удирдамж буюу СТОУС-ын Практикын Тунхаглал боловсруулах эсэхийг өөрийн *НББОУСЗ-ийн Баримт Бичгийн Нягтлах Шалгалт ба Засвар Сайжруулалтын Процесс*-ын дагуу харгалзан үздэг. Санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийн өөр өөр хэрэгцээ шаардлага бий болоход хүргэдэг янз бүрийн хэрэглэгчдийг *Онолын Үзэл Баримтлал*-ын 2-р бүлэгт заасан боловч уг Практикын Тунхаглалд тодорхойлсон хэрэглэгчид нь хөрөнгө оруулагчид байдаг учраас УСНББОУСЗ нь энэ хандлагыг тохиромжтой гэж үзээгүй. Иймээс улсын секторын хувьд тусгайлан хамаарах санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний талаархи заавар удирдамж боловсруулах нь чухал ач холбогдолтой гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлангийн тайлбарыг илүү гүн гүнзгий ойлголт болон хэтийн төлвөөр баяжуулж, нэмж гүйцээснээр хэрэглэгчдэд тусалцаа үзүүлдэг.
- ДҮ3. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь зарим улс оронд “удирдлагын хэлэлцүүлэг ба шинжилгээ”, “удирдлагын тайлбар дүгнэлт” гэж нэрлэдэг байж болох тайлан илтгэлүүд дэх ижил төсөөтэй асуудлуудыг авч үзэх санаа зорилготой байдаг. Гэвч УСНББОУСЗ нь санхүүгийн тайлантай холбоотой тайлан илтгэлийн шинж төрлийг эдгээр нэр томъёо үнэн зөв илэрхийлнэ гэж үзээгүй. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь дангаараа байх биш, харин тухайн санхүүгийн тайланг тайлбарлах санаа зорилготой тул санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг тэрхүү санхүүгийн тайлантай холбох нь чухал ач холбогдолтой гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн. “Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ШИНЖИЛГЭЭ

шинжилгээ” гэсэн нэр томъёо нь энэ СБПУ-ийн мөрдөгдөх боломжит байдлын цар хүрээ болон тухайн санхүүгийн тайланд түүний хамаарах нягт уялдаа холбоог оновчтой тодорхойлно гэж УСНББОУСЗ үзсэн.

### **Саналын Төсөл 47, Санхүүгийн Тайлангийн Хэлэлцүүлэг ба Шинжилгээ**

- ДҮ4. УСНББОУСЗ нь Саналын төсөл (СТ) 47, *Санхүүгийн Тайлангийн Хэлэлцүүлэг ба Шинжилгээ*-г боловсруулж, 2012 оны 3 дугаар сард гаргасан. Санхүүгийн тайлангаа УСНББОУС-ын дагуу бэлтгэж, толилуулдаг байгууллагууд н санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг бэлтгэх шаардлагатай гэдгийг энэхүү СТ-д илэрхийлсэн. Хэдийгээр санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь НЗСТ-тай холбоотой боловч аккруэл суурьт УСНББОУС-тай ижил түвшний бүрэн эрхтэй гэсэн утгыг үүгээр илэрхийлж байна.
- ДҮ5. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь санхүүгийн тайлангийн зорилтуудыг хангахад шаардлагатай нэмэлт мэдээллээр хангадаг гэж УСНББОУСЗ нь СТ-ийг боловсруулахдаа үзсэн. Түүнчлэн, санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний мэдээллийг тухайн санхүүгийн тайланг бэлтгэхдээ ашигладаг бөгөөд байгууллагын тусгайлсан нөхцөл байдалд нийцүүлэн тохируулдаг тул түүний үр өгөөж нь уг мэдээллийг бэлтгэх өртөг зардлаас илүү байна гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс УСНББОУС-ын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэдэг бүх байгууллагууд нь санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг бэлтгэх хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ санал болгосон.
- ДҮ6. Хэрэв байгууллагууд нь СТ-д санал болгосон (УСНББОУС байдлаар гаргасан) шаардлагуудыг даган мөрдөөгүй бол тухайн санхүүгийн тайланд мөрдөгдөх УСНББОУС-уудтай нийцсэн гэж илэрхийлж болохгүй гэдгийг уг СТ-д хариулт ирүүлсэн зарим хүмүүс илэрхийлсэн. Тухайлбал; санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь тухайн санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг биш гэдгийг СТ-д тодорхой заасан боловч санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг УСНББОУС-ын тайлагналын үзэл баримтлалын нэг хэсэг гэж үзсэн хэвээр байж болох юм гэдэгт тэдгээр хүмүүс санаа зовж байсан. Хэрэв албан журмын бус заавар удирдамж, тухайлбал Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ) байдлаар СТ-ийг боловсруулсан бол энэ нь асуудал биш гэдгийг тэдгээр хариулт ирүүлсэн зарим хүмүүс илэрхийлсэн.
- ДҮ7. СТ-ийг УСНББОУС эсвэл СБПУ байдлаар боловсруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь НЗСТ-д зориулсан эрх бүхий тунхаглалуудыг боловсруулж болох эсэх хүрээнд уг асуудлыг авч үзсэн бөгөөд гишүүд нь энэхүү асуудлын талаар янз бүрийн байр суурьтай байсан. Түүний *Онолын Үзэл Баримтлал*-ын цар хүрээ нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлангаар хязгаарлагдахгүй гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн.
- ДҮ8. СТ-д хариу ирүүлсэн хүмүүсийн санал энэ асуудал дээр хуваагдсан бөгөөд арай олонхи нь уг материалыг УСНББОУС болгохгүй гэдэг саналыг



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ШИНЖИЛГЭЭ

дэмжсэн. УСНББОУС болгож гаргахгүй гэсэн саналыг дэмжсэн, хариулт ирүүлсэн хүмүүсийн ихэнх нь уг санал болгосон СБПУ, *Байгууллагын Санхүүгийн Урт Хугацааны Тогтвортой Байдлын Тайлагнал*-тай ижил удирдамж байдлаар үүнийг гаргах хэрэгтэй гэсэн тодорхой байр суурийг илэрхийлсэн.

- ДҮ9. НЗСТ-ын нэлээд сайн тогтсон талбар болохын хувьд, санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний талаархи албан журмын тунхаглалууд нь тухайн байгууллагын өөрийн зүгээс түүний үйл ажиллагааны талаар гүнзгий ойлголт олж авах боломжийг хэрэглэгчдэд олгодог тул санхүүгийн тайлагналын хариуцлагын зорилгоо биелүүлэхэд байгууллагуудад тусалдаг. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь тухайн санхүүгийн тайлангийн тайлбар боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш тул энэ нь уг санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулгын хувьд шаардлагагүй юм.
- ДҮ10. Тэнцвэртэй байхын тулд уг СТ-ийг СБПУ байдлаар боловсруулах хэрэгтэй гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн. Энэхүү СБПУ нь байгууллагуудад ач холбогдолтой удирдамжаар хангах бөгөөд түүний уян хатан хэрэглээ нь орон нутгийн шаардлагууд болон зохицуулалт бүхий улс орны байгууллагуудын хувьд өгөөжтэй байж болох юм гэж УСНББОУСЗ үзсэн. Энэ нь санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг толилуулдаг байгууллагуудын хоорондох зэрэгцүүлэгдэх боломжтой байдалд бас дэмжлэг үзүүлдэг. Түүнчлэн, ийм мэдээллээр хэрэглэгчдийг хангахын тулд санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг толилуулж хэвшээгүй байгууллагуудад энэхүү СБПУ нь дэмжлэг үзүүлж болох юм гэж УСНББОУСЗ үзсэн.
- ДҮ11. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь санхүүгийн тайлагналын хариуцлагын зорилгыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулдаг учраас санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний энэхүү тунхаглалыг ирээдүйд албан журмын болгохоор харгалзан үзэх хэрэгтэй гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн.

### Хэтийн мэдээлэл

- ДҮ12. Байгууллага нь прогноз гэх мэт хэтийн мэдээллийг тодруулах талаар зөвлөмж гаргах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Зарим улс оронд, хэтийн мэдээлэл бэлтгэлтийг улс төрийн санаа зорилгын дохио илэрхийлэл, эсвэл ирээдүйн тодорхой ажиллагааны хувьд улсын секторын байгууллагад хариуцлага хүлээлгэлт гэж үзэж болно гэсэн болгоомжлолыг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Түүнчлэн, хэтийн мэдээллийг санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээнд тусган оруулж болох эсэх нь тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг зохицуулалтын болон төсвийн тайлагналын орчноос хамааран ялгаатай байдаг. Хэтийн мэдээллийг тусган оруулахгүй байх нь хэрэглэгчдийн шийдвэр гаргалтыг дэмжих уг санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээний боломж чадварт нөлөөлж болох тул түүнийг тусган оруулахыг зөвлөмж болгох хэрэгтэй гэсэн саналыг зарим гишүүд илэрхийлсэн. Гэвч байгууллага нь

хэтийн мэдээллийг тодруулах сонголт хийсэн бол ийм мэдээллээр хангаж болох боловч тэнцвэртэй байх үүднээс УСНББОУСЗ нь үүнийг зөвлөмж болгохгүй байхаар шийдвэрлэсэн.

### **Хэрэгжүүлэх заавар удирдамж ба үлгэрчилсэн жишээ**

ДҮ13. Чанарын шинжүүдийн Хэрэгжүүлэх Заавар Удирдамж, түүнчлэн байгууллагын санхүүгийн тайлан, хэлбэлзэл, хандлагын талаархи мэдээллийн үлгэрчилсэн жишээг СТ 47-д тусгасан. Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээг бэлтгэж буй байгууллагууд нь энэ СБПУ-ийн заавар удирдамжид голлон анхаарал хандуулах хэрэгтэй гэсэн үндэслэлээр УСНББОУСЗ нь Хэрэгжүүлэх Заавар Удирдамж болон үлгэрчилсэн жишээг хасахаар шийдвэрлэсэн. Түүнчлэн, УСНББОУСЗ нь хамгийн сайн практикын жишээг бусад эх үүсвэрээс олж авах боломжтой гэж үзсэн.

### **2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд СБПУ 2-д хийсэн хянан засварлалт**

ДҮ14. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь бүх УСНББОУС дахь хэллэгт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **СБПУ 3-ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ**

### **СБПУ-ийн түүх**

СБПУ 3, *Үйлчилгээний Гүйцэтгэлийн Мэдээллийн Тайлагнал*-ыг 2015 оны 3-р сард гаргасан.

Үүнээс хойш, СБПУ 3-д дараах УСНББОУС-уудаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал* (2016 оны 4 дүгээр сард гаргасан)

### **СБПУ 3-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт**

<b>Өөрчлөгдсөн параграф</b>	<b>Хэрхэн өөрчилсөн</b>	<b>Юугаар өөрчилсөн</b>
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

### АГУУЛГА

	Параграф
Зорилт	1
Төлөв байдал ба цар хүрээ	2-7
Тодорхойлолт	8-26
Үр дүнтэй байдал	10
Үр ашиг	11-12
Орц	13-14
Гарц	15-16
Үр дүн	17-19
Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд	20-22
Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд	23-26
Тайлагналын хил хязгаар	27-28
Жилийн тайлагнал ба тайлагналын үе	29-31
Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг толилуулах зарчмууд	32-37
Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн сонголт	38-71
Тайлагнах мэдээлэл	38-57
Тодруулах мэдээлэл	58-71
Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн байршил	72-75
Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн зохион байгуулалт	76-82
Дүгнэлтийн үндэслэл	
Үлгэрчилсэн жишээ	

## **Зорилт**

1. Энэхүү Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ) нь Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлан (НЗСТ)-д үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнах талаархи заавар удирдамжаар хангана. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь байгууллагын үзүүлдэг үйлчилгээ, байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд, тэдгээр зорилтуудын биелэлтийн хэмжээний талаархи мэдээлэл юм. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь байгууллагын үйлчилгээний үр ашигтай ба үр дүнтэй байдлыг үнэлэхэд НЗСТ-гийн хэрэглэгчдэд (цаашид “хэрэглэгчид” гэх) тусалдаг.

## **Төлөв байдал ба цар хүрээ**

2. Энэхүү СБПУ-ийн дагуу хийгдэх мэдээллийн тайлагнал нь сайн практикыг илэрхийлнэ. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнаж буй байгууллага нь энэ СБПУ-д заасан зарчмуудыг биелүүлэхээр эрмэлзэх хэрэгтэй. Байгууллага нь өөрийн санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-д нийцсэн гэж мэдэгдэхийн тулд энэхүү СБПУ-ийг даган мөрдсөн байхыг шаардахгүй.
3. Хэдийгээр энэхүү СБПУ нь улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудад шууд хамаарахгүй боловч уг тайлагнагч байгууллагын хяналтанд буй улсын секторын худалдаа арилжааны байгууллагын үзүүлсэн үйлчилгээ нь энэ СБПУ-ийн цар хүрээнд хамаарна.
4. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь энэ СБПУ-ийн бүх зарчмуудтай нийцсэн байхаас бусад тохиолдолд түүнийг энэ СБПУ-тай нийцсэн гэж тодорхойлж болохгүй.
5. Энэ СБПУ нь толилуулах мэдээллийг тодорхойлдог. Нэмэлт мэдээлэл нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд ач холбогдолтой бөгөөд санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг хангаж байвал байгууллага нь тийм мэдээллийг толилуулж болно.
6. Зарим улс орны хувьд, үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн толилуулга нь хууль тогтоомж буюу зохицуулалтын шаардлага байдаг. Энэхүү СБПУ-ийн даган мөрдөлтөнд ийм шаардлагуудын үзүүлэх үр нөлөөний талаархи мэдээллийг байгууллагууд нь тодруулахыг сайшаан дэмжинэ.
7. Улс орон нь энэ СБПУ-ийн удирдамжаас илүү давсан, үйлчилгээний гүйцэтгэлийн тайлагналын шаардлагуудыг тогтоож болох юм. Үүнд тухайлбал дараах зүйлс хамаарч болно: шаардлагатай мэдээллийн зохион байгуулалтын илүү тусгайлсан тодорхойлолт, тайлагнах буюу тодруулах илүү цогц мэдээллийн шаардлага, гүйцэтгэлийн тусгайлсан үзүүлэлтүүд ба/буюу толилуулах шаардлагатай гүйцэтгэлийн тусгай төрлүүд. Ийм тохиолдолд байгууллага нь энэхүү удирдамж ба улс орны шаардлагын аль алиныг мөрдсөнөөр уг мэдээллийг тодорхойлсон эсэхийг ханган магадлахыг сайшаан дэмжинэ.

## Тодорхойлолт

8. Энэ СБПУ-д дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:

Үр дүнтэй байдал гэдэг нь гүйцэтгэлийн үр дүн ба үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын хоорондох харилцан хамаарал юм.

Үр ашиг гэдэг нь (а) орц ба гарцын, эсвэл (б) орц ба үр дүнгийн хоорондох харилцан хамаарал юм.

Орц гэдэг нь гарцыг бий болгохын тулд байгууллагын ашиглаж буй нөөц юм.

Гарц гэдэг нь байгууллагын хувьд гаднын байх хүлээн авагчдад уг байгууллагын үзүүлдэг үйлчилгээ юм.

Үр дүн гэдэг нь тухайн байгууллагын гарцын үр дүн байдлаар үүсдэг буюу түүнтэй ул үндэслэлтэй хамааралтайгаар нийгэмд үзүүлэх үр нөлөө юм.

Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд гэдэг нь тоон хэмжүүр, чанарын хэмжүүр ба/буюу байгууллага нөөцийг ашиглах, үйлчилгээг үзүүлэх болон өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудыг биелүүлэх хэмжээ ба шинж төрлийн талаархи чанарын шинжтэй тайлбар тодорхойлолт юм.

Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилт гэдэг нь орц, гарц, үр дүн, үр ашгийн нөхцлөөр илэрхийлсэн уг байгууллагын хүрэхээр эрмэлзэж буй тухайн төлөвлөсөн үр дүн (үр дүнгүүд)-ийн тайлбар тодорхойлолт юм.

9. СБПУ 3-ыг дагалдах Хэрэгжүүлэлтийн Жишээнд дээр дурдсан нэр томъёог үлгэрчлэн харуулсан.

### Үр дүнтэй байдал

10. Байгууллагын үр дүнтэй байдлыг тайлагнах үедээ тухайн байгууллага нь өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн нэг буюу хэд хэдэн зорилтуудад хүрсэн хэмжээг тайлагнадаг. Үйлчилгээ үзүүлэгч байдлаар тухайн байгууллага нь илүү үр дүнтэйгээр ажиллах тусам түүний төлөвлөсөн үр дүнтэй харьцуулан хэмжсэн гүйцэтгэлийн үр дүн илүү сайн байдаг.

### Үр ашиг

11. Дараах гэх мэт зүйлстэй харьцуулахад үйлчилгээг илүү (эсвэл арай бага) үр ашигтайгаар үзүүлж буй эсэхийг харуулахын тулд үр ашгийн үзүүлэлтийг ашиглаж болно:

- (а) Өмнөх тайлант үеүд;
- (б) Хүлээлт;
- (в) Зэрэгцүүлэгдэх үйлчилгээ үзүүлэгчид; эсвэл,
- (г) Бенчмарк үзүүлэлтүүд.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

12. Ижил тоо хэмжээ ба чанар бүхий гарцыг өмнө байснаас арай бага өртгөөр үйлдвэрлэж байвал үйлдвэрлэлийн үр ашиг дээшилсэн байх бөгөөд ийм төрлийн үр ашгийг тайлагнах зориулалт бүхий үр ашгийн үзүүлэлт нь сайжралтыг илтгэн харуулна. Үүнтэй адилаар, үйлчилгээний тоо хэмжээ (гарц) ба өртөг гэх мэт бусад хувьсагчид тогтмол байхад үйлчилгээний чанар сайжирсан, ингэснээр хүрсэн үр дүн нь өмнөх үр дүнгээс илүү сайн байсан бол энэ нь үр ашиг нэмэгдсэнийг илэрхийлэх бөгөөд ийм төрлийн үр ашгийг тайлагнах зориулалт бүхий үр ашгийн үзүүлэлт нь сайжралтыг илтгэн харуулна. Харин эсрэгээр, үйлчилгээний тоо хэмжээ (гарц) ба өртөг гэх мэт бусад хувьсагчид тогтмол байхад үйлчилгээний чанар буурсан, ингэснээр үр дүн муу байсан бол энэ нь үр ашиг багатай үйлчилгээ үзүүлснийг илтгэн харуулна

### Орц

13. Гарцыг бий болгоход ашигласан нөөцөд дараах зүйлс хамаарч болох юм:
- (a) Хүний нөөц буюу хөдөлмөр;
  - (б) Газар, барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл гэх мэт капитал хөрөнгө;
  - (в) Мөнгө ба бусад санхүүгийн хөрөнгө;
  - (г) Оюуны өмч гэх мэт биет бус хөрөнгө.
14. Гарцыг бий болгохын тулд гаргасан өртөг зардал буюу ашигласан тоо хэмжээгээр орцыг тайлагнаж болно.

### Гарц

15. Гаднын хүлээн авагчдад тухайн байгууллагын үзүүлдэг үйлчилгээнд дараах зүйлс хамаарна:
- (a) Хувь хүмүүс болон байгууллагуудад шууд үзүүлсэн үйлчилгээ – жишээлбэл; эрүүл мэндийн буюу боловсролын үйлчилгээ, эсвэл хүнс, ном гэх мэт барааны нийлүүлэлт;
  - (б) Хувь хүмүүс болон байгууллагуудад шууд бусаар үзүүлсэн үйлчилгээ – жишээлбэл; олон нийт, байгууллага, улс орон, нийгмийн үнэ цэнэт зүйлс болон эрхийг хөгжүүлэх, дэмжих, хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ;
  - (в) Хувь хүмүүс болон байгууллагуудад олгосон шилжүүлэг – жишээлбэл; мөнгөн шилжүүлэг ба татварын урамшуулал гэх мэт эдийн засгийн урамшуулал үзүүлэлт;
  - (г) Төрийн бодлогын зорилтуудыг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалт буюу хууль тогтоомж, үүнд тухайлбал, хууль тогтоомж болон тухайн хууль тогтоомжийн хэрэгжүүлэлттэй холбоотой орлого; ба
  - (д) Татварын болон бусад орлогын хураалт.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

16. Тухайн байгууллагын хувьд гаднын байх хүлээн авагч нар тэрхүү үйлчилгээг хүлээн авалт нь уг байгууллагын гарцын үйлдвэрлэлийн нэг хэсэг байдлаар дотооддоо зарцуулсан үйлчилгээ биш, харин гарц эсэхийг шийдвэрлэх чухал хүчин зүйл юм.

### Үр дүн

17. Байгууллагын үр дүн нь нийгэмд бүхэлд нь, уг нийгмийн хүрээн дэх тодорхой бүлгүүд буюу байгууллагуудад нөлөөлөх үр дагавартай байж болно. Гарц нь тухайн байгууллагын үйлчилгээг хүлээн авагчдад харьцангуй шууд нөлөө үзүүлж болох юм. Энэ нь тухайн байгууллагын үйлчилгээг хүлээн авагчид биш боловч тэдгээр үйлчилгээнээс шууд бусаар өгөөж хүртдэг бусад талуудад бас нөлөөлж болно.
18. Үр дүнд тухайлбал; тухайн нийгмийн боловсролын түвшний өөрчлөлт, ядуурлын болон гэмт хэргийн түвшний өөрчлөлт, нийгмийн янз бүрийн бүлгүүдийн эрүүл мэндийн өөрчлөлт хамаарч болох юм.
19. Тухайн байгууллагын үйл ажиллагаа ба түүний үр дүнгийн хооронд тохиолдлын шинжтэй хүчтэй, шууд хамаарал байж болох боловч ийм тохиолдол байнга гараад байдаггүй. Тухайн байгууллагын хяналтаас ангид хүчин зүйлс нь түүний үр дүнгийн биелэлтэнд саад учруулах эсвэл дэмжлэг үзүүлэх байдлаар нөлөөлж болох юм.

### Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

20. Орц, гарц, үр дүн, үр ашиг, үр дүнтэй байдал нь гүйцэтгэлийн үзүүлэлтийн төрлүүд юм.
21. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь тоон хэмжигдэхүүн байж болно. Жишээлбэл; үйлдвэрлэсэн гарцын тоо хэмжээ, үйлчилгээний өртөг, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулсан хугацаа, үр дүнгийн тоон зорилтот түвшин. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь чанарын хэмжигдэхүүн байж болно. Жишээлбэл; үйлчилгээ хүлээн авагчид, иргэд, мэргэжилтнүүдийн үйлчилгээний чанарын үнэлэмжийг тусгаж болох муу/сайн/маш сайн эсвэл хангалттай/хангалттай бус гэх мэт тодорхойлогч үзүүлэлт. Тоон болон чанарын хэмжигдэхүүнүүдийг ашиглах нь дараах зүйлсийн хувьд хэрэглэгчдэд тусалцаа үзүүлж болох юм:
  - (а) Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд хангагдсан эсэх талаархи тэдний үнэлгээ; ба
  - (б) Үйлчилгээний гүйцэтгэлийн талаархи тайлант үе хоорондын болон байгууллага хоорондын зэрэгцүүлэлт.
22. Гүйцэтгэлийн үзүүлэлт нь мөн чанарын тайлбар тодорхойлолт хэлбэртэй байж болно. Тухайн үйлчилгээний хувьд ихээхэн нарийн төвөгтэй нөхцөл байдалтай бөгөөд шүүн тунгаалт хийх шаардлагатай тохиолдолд үйлчилгээний гүйцэтгэлийн талаар хамааралтай ба ойлгомжтой мэдээллээр хэрэглэгчдийг хангахад ийм чанарын тайлбар тодорхойлолт зайлшгүй шаардлагатай байж болох юм.



### **Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд**

23. Орц, гарц, үр дүн, үр ашиг гэсэн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг, эсвэл энэхүү дөрвөн үзүүлэлтийн нэг буюу хэд хэдэн үзүүлэлтийг хослуулан ашигласнаар үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудыг илэрхийлж болох юм. Үйлчилгээ үзүүлсний үр дүнд хүссэн ирээдүйн төлөв байдлын талаархи хүүрнэсэн тайлбар тодорхойлолтыг ашигласнаар үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудыг бас илэрхийлж болно.
24. Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд нь ерөнхийдөө тодорхой, хэмжиж, хүрч болох ба бодитой, цаг хугацааны хязгаартай байна.
25. Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудыг тухайн төрлийн гүйцэтгэлийн үзүүлэлтээр бас илэрхийлж болно. Жишээлбэл; бүгдийг нь үр дүнгээр илэрхийлэх. Мөн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудыг өөр өөр төрлийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээр илэрхийлж болно. Жишээлбэл; үйлчилгээний гүйцэтгэлийн зарим зорилтуудыг үр дүнгээр, өөр заримыг гарц ба/буюу орцоор илэрхийлж болох юм.
26. Нэг үйлчилгээ нь үйлчилгээний гүйцэтгэлийн нэг буюу хэд хэдэн зорилтуудын биелэлтэнд хувь нэмрээ оруулж болох юм. Хэд хэдэн үйлчилгээ нь үйлчилгээний гүйцэтгэлийн нэг ижил зорилтод хувь нэмрээ оруулж болох юм.

### **Тайлагналын хил хязгаар**

27. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагналын хувьд байгууллагын тайлагналын хил хязгаар нь тухайн санхүүгийн тайланд ашигладаг хил хязгаартай ижил байвал зохино.
28. Толилуулж буй гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь уг хяналт тавигч байгууллагын өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудад хамааралтай байна. Хяналтанд буй байгууллагуудын санхүүг нэгтгэн толилуулдаг нэгтгэсэн санхүүгийн тайлангаас ялгаатай нь, хяналт тавигч байгууллагын тайлагнадаг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь түүний хяналтанд буй байгууллагуудын тайлагнасан үйлчилгээнүүдийн нэгтгэл ихэвчлэн биш байдаг.

### **Жилийн тайлагнал ба тайлагналын үе**

29. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг наад зах нь жил бүр тайлагнах хэрэгтэй.
30. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь тухайн санхүүгийн тайланд хамаарах тайлант үетэй ижил тайлагналын үеийг хамарсан байвал зохино. Гэвч хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагын хянамгай хэлэлцүүлэг, түүнчлэн өртөг-өгөөжийн үнэлгээ нь тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн хамрах тайлант үеэс өөр тайлагналын үе байх хэрэгтэй гэдгийг илэрхийлж болох юм. Тухайлбал; хяналт тавигч байгууллагын толилуулсан

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь өөр өөр тайлант үе бүхий хяналтанд буй байгууллагуудын тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэлд үндэслэдэг бол ийм тохиолдол үүсэж болно.

31. Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд нь тэдгээрийг биелүүлэхэд нэг жилээс урт хугацааг шаардаж болох юм. Ийм олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудад чиглэсэн явц өрнөлийн талаархи мэдээлэл нь хэрэглэгчдэд шаардлагатай байдаг. Олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудад чиглэсэн жилийн явц өрнөлийг харуулахын тулд толилуулж болох үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн төрлийг 53-р параграфт авч үзсэн.

### **Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг толилуулах зарчмууд**

32. Байгууллага нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдэд ач холбогдолтой үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг толилуулах хэрэгтэй. Уг толилуулга нь байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн хэмжээ, үр ашиг, үр дүнтэй байдлыг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог байвал зохино. Энэ нь байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудад тохиромжтой бөгөөд уг байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд ба түүний үйлчилгээний гүйцэтгэлийн биелэлтийн хоорондох хамаарлыг тодорхой болгодог байвал зохино.
33. Байгууллагын санхүүгийн тайлангийн мэдээлэлтэй нэгтгэн ашиглах тохиолдолд уг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь тэрхүү үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын биелэлтийн хүрээнд тухайн байгууллагын санхүүг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог байвал зохино. Нөгөө талаас, уг байгууллагын санхүүгийн хүрээнд, үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын биелэлтийг үнэлэх боломжийг мөн олгодог байх хэрэгтэй.
34. Уг толилуулсан үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь дараах гэх мэт уг байгууллагын тусгайлсан нөхцөл байдлуудыг харгалзсан байвал зохино:
- (а) Байгууллагын үзүүлдэг үйлчилгээ;
  - (б) Байгууллагын шинж төрөл; ба
  - (в) Байгууллагын үйл ажиллагаа явуулдаг зохицуулалтын орчин.
35. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн толилуулга нь НЗСТ дахь мэдээллийн түгээмэл хязгаарлалтыг мөрдөхийн зэрэгцээгээр санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг хангадаг байвал зохино. (*Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* (Онолын Үзэл Баримтлал)-д чанарын шинжүүд болон хязгаарлалтуудыг тайлбарласан.)
36. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн нэгтгэн нийлүүлэлт буюу салган задлалт нь тухайн байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн биелэлтийн талаархи ач холбогдолтой ойлголтыг агуулах тийм түвшинд байвал зохино.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

Нэгтгэн нийлүүлэлтийн түвшин нь гүйцэтгэлийг нуун далдлах буюу бүрхэгдүүлэх тийм өндөр түвшний биш, харин салган задлалтын түвшин нь гүйцэтгэлийг бас бүрхэгдүүлэх ба ойлгомжтой байдлыг бууруулах дэлгэрэнгүй жагсаалт бий болгоход хүргэх тийм доод түвшний биш байвал зохино. Тайлагнасан мэдээлэл нь өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн хувьд, ялангуяа үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын хэрэгжилтийн хувьд тухайн байгууллагыг хариуцлагатай байлгахын тулд хэрэглэгчдэд хангалттай тусгайлан зориулагдсан байх хэрэгтэй.

37. Янз бүрийн үйлчилгээ үзүүлдэг учраас бусад байгууллагуудтай зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн хувьд биелүүлэхэд төвөгтэй байж болох юм. Хэдийгээр хоёр байгууллага нь яг ижил үйлчилгээ үзүүлдэг боловч тэд гүйцэтгэлийн үл зэрэгцүүлэгдэх, янз бүрийн үзүүлэлтээр тайлагнах шаардлагатай байх тийм үр дүн бүхий үйлчилгээний гүйцэтгэлийн өөр өөр зорилтуудтай байж болно. Тухайн байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн нөхцөл байдалд хамааралтай тийм үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд болон тэдгээрийн холбогдох гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг сонгохын тулд байгууллага хоорондын зэрэгцүүлэгдэх боломжтой байдлыг хамааралтай байдалтай харьцуулж, тэнцвэрийг олох шаардлагатай байж болох юм. Нөгөө талаас, ижил үйлчилгээ үзүүлдэг бусад байгууллагуудын үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлж болох гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь тухайн байгууллагад хамааралтай бөгөөд зэрэгцүүлэгдэх боломжтой байдал, хамааралтай байдал гэсэн чанарын хоёр шинж нь харилцан холбоотой болохыг хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага илэрхийлж болох юм.

### Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн сонголт

#### Тайлагнах мэдээлэл

38. Дараах мэдээллийг тайлагнах хэрэгтэй:
- (а) Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд;
  - (б) Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд; ба
  - (в) Үйлчилгээний нийт өртөг.
39. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд ба үйлчилгээний нийт өртгийн хувьд байгууллага нь дараах зүйлсийг тайлагнах хэрэгтэй:
- (а) Тухайн тайлант үеийн төлөвлөсөн болон гүйцэтгэлийн мэдээлэл; ба
  - (б) Өмнөх тайлант үеийн гүйцэтгэлийн мэдээлэл.
40. Санхүүгийн тайланд бас тусгадаг мэдээллийг уг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл агуулдаг тохиолдолд санхүүгийн тайланд тайлагнасан санхүүгийн мэдээллийн хүрээнд хэрэглэгчид нь тэрхүү мэдээллийг үнэлэх боломжтой болгохын тулд тухайн санхүүгийн тайланд хийсэн харилцан лавлагааг толилуулах хэрэгтэй.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

41. Байгууллагын хууль тогтоомжийн болон төлөвлөлтийн баримт бичигт (төсвийн мэдэгдэл, эрхэм зорилгын мэдэгдэл, стратегийн төлөвлөгөө, санхүүжилтийн хэлцэл, хамтын ажиллагааны төлөвлөгөө гэх мэт) тусгасан мэдээлэл нь тухайн байгууллагад хамааралтай үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд болон гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тодорхойлоход ихэвчлэн туслалцаа үзүүлдэг.

### *Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд*

42. Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд өөрчлөгдсөн тохиолдолд тухайн толилуулж буй мэдээлэл нь уг өөрчлөлтийг тусгасан байвал зохино. Жишээлбэл; байгууллага нь эхлээд өөрийн үйлчилгээтэй холбоотой орц эсвэл гарцын аль нэгийг нэмэгдүүлэхтэй холбоотой үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудтай байсан боловч дараа нь, уг үйлчилгээний үр ашиг буюу үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхэд гүйцэтгэлээ өөрчлөн чиглүүлж болох юм. Ийм өөрчлөлтийг тухайн байгууллагын толилуулж буй үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэлд тусгах хэрэгтэй.

### *Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд*

43. Тайлагнахад хамгийн тохиромжтой гүйцэтгэлийн цогц үзүүлэлтүүдийг тодорхойлохын тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Тэргүүлэх ач холбогдлын зарчим нь хэрэглэгчдэд тэдний ач тустай байдал ба өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудад тухайн байгууллагын хүрсэн амжилтыг үнэлэхэд тэдний ач холбогдолтой байдлыг харгалзан үзүүлэлтүүдийг сонгодог. Хамааралтай байхын тулд гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь тухайн байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн нэг буюу хэд хэдэн зорилтуудтай шууд холбоотой байдаг. Толилуулж буй янз бүрийн үзүүлэлтүүдийн, тухайлбал орц, гарц, үр дүнгийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн, түүнчлэн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын хоорондох нийцтэй байдал нь нөөц ба хүрсэн үр дүнгийн хоорондох уялдаа, үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын хэрэгжилтэд уг нөөцийн бэлэн боломжтой байдал хэрхэн нөлөөлж болох эсэхийг үнэлэхэд хэрэглэгчдэд тусалдаг.
44. Толилуулсан гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь тухайн байгууллага үйлчилгээ үзүүлэх ба өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудыг биелүүлэхдээ нөөцийг хэрхэн үр ашигтай, үр дүнтэй ашигласныг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог.
45. Байгууллага нь төлөвлөсөн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг олон нийтэд нээлттэй тайлагнадаг тохиолдолд уг толилуулсан бодит гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь олон нийтэд өмнө нь тайлагнасан үзүүлэлтүүдтэй ихэвчлэн нийцсэн байдаг. Өөрсдийн төсвийн мэдээллийг хэвлэн нийтэлдэг бөгөөд УСНББОУС 24, *Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга-ыг* мөрддөг байгууллагууд нь уг мэдээлэл болон өөрийн тайлагнадаг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн хоорондох уялдаа холбоог харгалзан үзвэл зохино.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

46. Байгууллага нь өөрийн зорьж буй үр дүн ба тэдгээр үр дүнгийн биелэлтийн талаархи мэдээллээ тайлагнахыг сайшаан дэмжинэ.
47. Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын хувьд толилуулж болох гүйцэтгэлийн маш олон үзүүлэлтүүд байж болно. Мэдээллийн ойлгомжтой байдлыг хангах ба хэрэглэгчдийг хэт мэдээллээр дарахаас зайлсхийхийн тулд ерөнхийдөө, байгууллагууд нь хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хамгийн сайн хангах ба санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэх зөвхөн тэдгээр цөөн гол гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тодорхойлох шаардлагатай байдаг.
48. Тоон хэмжигдэхүүн агуулсан гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг найдвартай хэмжих боломжтой байвал зохино. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг ажил гүйлгээний боловсруулалтын системээр бий болгодог тохиолдолд ийм системийн ашиглалт нь уг тайлагнасан мэдээллийн шалгах боломжтой ба цаг хугацаандаа байх нөхцлийг дэмждэг.
49. Уг толилуулсан үзүүлэлтүүд нь үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын биелэлтийг төлөөлөх үнэн зөв тайлбар тодорхойлолтоор хангах эсэхийг байгууллага нь гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг сонгохдоо ханган магадлах хэрэгтэй. Нэг төлөв байдал сайжирч, нөгөө төлөв байдал муудах гэх мэт үйлчилгээний гүйцэтгэлийн янз бүрийн төлөв байдлуудын хоорондох тэнцвэрийг тогтоож болох юм. Толилуулсан мэдээлэл нь төв голч байвал зохино. Эерэг үр дүн тайлагнахад чиглэсэн хэт нэг тал руу хэлбийсэн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд толилуулах аливаа хандлагаас байгууллага нь зайлсхийх хэрэгтэй. Ингэснээр чанарын үзүүлэлтүүд хангагдсан ба тухайн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь уг байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн гэдэгт хэрэглэгч нар итгэлтэй байдлыг ханган магадлахад тусалдаг.
50. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг сонгохдоо хэмжилтийн хялбар байдлыг харгалзах магадлалтай боловч энэ нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагаас хоёрдугаарт байвал зохино. Толилуулсан гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь хэмжихэд хялбар хэмжигдэхүүнүүдэд хэт ач холбогдол өгөх шаардлагагүй юм.
51. Зарим нөхцөл байдалд, чанарын шинжтэй тайлбар тодорхойлолтыг (хүүрнэсэн мэдээлэл гэж бас нэрлэдэг) гүйцэтгэлийн үзүүлэлт байдлаар толилуулах хэрэгтэй. Үйлчилгээ нь дараах шинж чанартайн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн биелэлтийг тоон буюу чанарын хэмжилтийн жижиг багц хүртэл бууруулах боломжгүй тохиолдолд ийм нөхцөл байдал үүсэж болно:
- (а) Нарийн цогц;
  - (б) Харилцан холбоотой хүчин зүйлсийг агуулдаг; ба
  - (в) Амжилт буюу явц өрнөлийн боломжит янз бүрийн маш олон үзүүлэлтүүдийг агуулдаг бөгөөд эдгээрийн бүгдийн хувьд, тэдний харьцангуй ач холбогдлын талаархи шүүн тунгаалтыг хийдэг.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

52. Аливаа нэг үйлчилгээний хувьд тайлагнасан мэдээлэл нь гүйцэтгэлийн нэг буюу хэд хэдэн өөр төрлийн үзүүлэлтүүд, тоон хэмжүүр, чанарын шинжтэй хэмжүүр, чанарын тайлбар тодорхойлолтыг агуулсан байж болно.

*Олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд ба гүйцэтгэлийн үзүүлэлтүүд*

53. Олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн хувьд явц өрнөлийг тайлагнах өртөг зардлын хэмнэлттэй арга замыг боловсруулах шаардлагатай байж болох боловч олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн уртасгасан хугацааны хамрах хүрээ нь олон жилийн зорилтуудын тайлагнал болон тэдгээрийн биелэлтийн явц өрнөлийн тодруулгад саад учруулдаггүй байвал зохино. Олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтын биелэлтийн талаархи мэдээлэл бэлэн боломжтой болох хүртэл уг үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтын биелэлтэнд чиглэсэн явц өрнөлийг илэрхийлэх хувилбар буюу төлөөлөх хэмжүүрийг богино хугацаагаар толилуулах боломжтой байж болох юм. Жишээлбэл; байгууллага нь үйлчилгээний нэг буюу хэд хэдэн талбарын хувьд жил тутмын гарцууд болон урт хугацааны, олон жилийн үр дүнгүүдийг тогтоодог тохиолдолд тэдгээр үр дүнд хүрэхэд чиглэсэн явц өрнөлийн илэрхийлэл болгон гарцын жил тутмын тайлагналыг арай урт хугацаагаар тайлагнасан бодит үр дүнгээр илэрхийлэх тийм цар хүрээтэй байж болох юм.

*Үйлчилгээний нийт өртөг ба өртгийн салган задалсан мэдээлэл*

54. Үйлчилгээний нийт өртгийг тайлагнахаас гадна байгууллага нь өртгийн салган задалсан мэдээллийг бас толилуулах сонголт хийж болно. Өртгийн салган задалсан мэдээлэл нь тухайлбал, үйлчилгээний гүйцэтгэлийн бие даасан зорилтууд, үр дүнгүүд, үйлчилгээний талбарууд, бие даасан үйлчилгээнүүдтэй холбоотой өртөг зардал, гарцын өртгүүд эсвэл тухайн тодорхой орцуудад хамаарах өртөг зардал байж болно. Гарц буюу үр дүнгийн аль нэгэнд хамаарах өртөг зардлын нөөц сангаар үр ашгийн талаархи хэрэглэгчдийн үнэлгээг дэмжин баталгаажуулж болох юм.

*Үйлчилгээний төлөвлөсөн ба бодит гүйцэтгэл*

55. Үр дүнтэй байдлын талаархи хэрэглэгчдийн үнэлгээнд дэмжлэг үзүүлэхийн тулд үйлчилгээний төлөвлөсөн ба бодит гүйцэтгэлийн мэдээллийг тууштай тайлагнах хэрэгтэй. Боломжтой тохиолдолд байгууллага нь уг тайлагналын үе эхлэхээс өмнө тогтоосонтой ижил арга зүй, хүчин зүйлсийг өөрийн тооцоололд ашиглаж, гүйцэтгэлийн ижил үзүүлэлтүүдээр тайлагнаж байх хэрэгтэй. Энэ нь тухайн тайлагналын үеийн эцэст бодит гүйцэтгэлийг төлөвлөсөн гүйцэтгэлтэй харьцуулах боломжийг хэрэглэгчдэд олгодог.
56. Хэд хэдэн жилийн хугацаанд гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тууштай мөрдөх нь урт хугацааны хандлагын шинжилгээ хийх боломж бүрдүүлдэг. Гэвч ийм тууштай байдлыг хадгалахын тулд дараах зүйлсийг орхигдуулж болохгүй:
- (а) Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн чанарыг сайжруулах; эсвэл,

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

(б) Сонирхогч талуудын өөрчлөгдсөн хүлээлттэй үзүүлэлтүүдийг нийцүүлэх.

57. Төлөвлөсөн үйлчилгээний гүйцэтгэлд тухайн тайлант үеийн туршид орсон өөрчлөлтийг хэрхэн тайлагнах талаархи асуудлыг байгууллага нь харгалзан үзэх шаардлагатай байж болох юм. Тухайлбал; сонирхогч талууд нь үйлчилгээний гүйцэтгэлийн талаархи өөрсдийн хүлээлтийг тухайн тайлант үеийн туршид өөрчилсөн, ингэснээр үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудад нэмэлт өөрчлөлт оруулахад хүргэсэн тохиолдолд ийм нөхцөл байдал үүсэж болно. Үйлчилгээний хариуцлагыг нэг байгууллагаас нөгөөд шилжүүлсэн, эсвэл өмнө нь хоёр байгууллагын үзүүлдэг байсан үйлчилгээг нэгдэж нийлсэн нэг байгууллага одоо үзүүлдэг болсноор тайлагналын шаардлага үүсгэх тийм улсын секторын нэгдлийн үр дүнд үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд бас өөрчлөгдөж болох юм. Ийм нөхцөл байдалд байгууллага нь үйлчилгээний гүйцэтгэлийн анхны болон хянан засварласан зорилтуудын аль алиныг тайлагнах боломжтой байж болно. Бодит биелэлтийн хэмжээг уг үйлчилгээний гүйцэтгэлийн илүү шинэлэг, хянан засварласан зорилтуудтай бас харьцуулан ойлгохын зэрэгцээгээр, хэрэглэгчид нь тухайн тайлант үеийн эхэн дэх үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд ба бодит биелэлтийн хоорондох зөрүү хэлбэлзлийн шалтгааныг ойлгоход шаардлагатай мэдээлэлтэй байхын тулд тэдгээр өөрчлөлтийн шалтгаан, нөлөөллийг хүүрнэсэн хэлэлцүүлэг болон шинжилгээ хэсэгт тайлбарлан илэрхийлж болно.

### **Тодруулах мэдээлэл**

58. Хэрэглэгчдэд дараах боломж олгохын тулд ямар мэдээллийг тодруулах хэрэгтэй эсэхийг шийдвэрлэхийн тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг:

(а) Тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн суурийг ойлгох; ба,

(б) Тухайн байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн талаархи өөрсдийн үнэлгээнд хамааралтай гол асуудлуудыг онцлон тэмдэглэсэн, үйлчилгээний гүйцэтгэлийн товч тойм мэдээг хүлээн авах.

### *Тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн суурь*

59. Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, нийт өртгийн талаархи мэдээлэл нь санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг хангаж буй эсэхийг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгохын тулд байгууллага нь уг тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн суурийн хувьд хангалттай мэдээллийг тодруулах хэрэгтэй.

60. Байгууллага нь тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн эх сурвалжийн талаархи мэдээллийг тодруулах хэрэгтэй.

61. Дараах мэдээллийг тодруулвал зохино:

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

- (a) Тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын тайлбар, энэ нь зорилтуудыг хэрхэн тогтоосон эсэх, тэдгээрийг биелүүлэх хэрэгцээ шаардлага, үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд ба дараах зүйлсийн хоорондох уялдаа холбоог тайлбарлан тодорхойлдог:
  - (i) Тайлагнасан гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, ба
  - (ii) Байгууллагын ерөнхий зорилтууд.
- (б) Холбогдох гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн хоорондох уялдаа холбооны тайлбар. (Жишээлбэл; орц ба гарц нь тухайн үр дүнгийн биелэлтэнд хувь нэмрээ оруулдаг тохиолдолд орц, гарц ба/буюу үр дүнгийн үзүүлэлтүүдийн хоорондох нийцлийн хэмжээний талаархи мэдээлэл)
- (в) Мэдээллийн нэгтгэн нийлүүлэлтийн (эсвэл салган задлалтын) суурийн талаархи тайлбар, энэ нь тайлагнасан дэлгэрэнгүй байдлын түвшинг харгалзан үздэг.

### Өртгийн талаархи салган задалсан мэдээлэл

- 62. Хэрэв байгууллага нь өртгийн талаархи салган задалсан мэдээллийг толилуулах сонголт хийсэн бол өртгийн тодорхойлолтын суурийг тодруулах хэрэгтэй.
- 63. Өртөг тодорхойлолтын мэдээлэл нь дараах гэх мэт мэдээллийг агуулсан байдаг:
  - (a) Өртөг хуваарилалтын бодлого;
  - (б) Үйлчилгээтэй холбоотой шууд ба шууд бус зардлын бүртгэлийн арга; ба/буюу
  - (в) Толилуулсан үйлчилгээний өртөг ба нийт зардлын хоорондох тохируулга буюу зэрэгцүүлэлт.

### Хяналт тавигч байгууллагын тодруулга

- 64. Хяналт тавигч байгууллага нь өөрийн хяналтанд буй байгууллагуудын үзүүлсэн үйлчилгээний талаар тайлагнадаг тохиолдолд уг хяналт тавигч байгууллага нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх үйлчилгээний гүйцэтгэлийн хувьд тэдгээрийн тус бүрийн үүрэг ба хариуцлагыг тайлбарласан мэдээллийг тодруулах хэрэгтэй.

### Тайлагналын үе нь өөр байх тохиолдол дахь тодруулга

- 65. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн тайлант үеэс өөр тайлагналын үеийг хамардаг тохиолдолд дараах мэдээллийг тодруулах хэрэгтэй:
  - (a) Уг тайлагналын үе нь тухайн санхүүгийн тайлангийн тайлант үетэй ижил биш байгаа тухай;



## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

- (б) Ийм өөр байгаагийн шалтгаан; ба
- (в) Үйлчилгээний гүйцэтгэлийн тайланд санхүүгийн мэдээллийг тусган оруулсан бол дараах зүйлсийн аль нэгийг тодруулах:
  - (i) Мэдээллийг олж авсан тухайн санхүүгийн тайлангийн тайлант үеийг тэдгээр санхүүгийн тайлантай танилцахад туслалцаа үзүүлэх мэдээллийн хамтаар; эсвэл
  - (ii) Хэрэв мэдээллийг тухайн байгууллагын санхүүгийн тайлангаас аваагүй бол уг тайлагнасан санхүүгийн мэдээллийн эх сурвалжийг тэрхүү эх сурвалжтай танилцахад туслалцаа үзүүлэх мэдээллийн хамтаар.

66. Зарим үйлчилгээний талаархи мэдээллийн тайлагналын үе нь тухайн байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн тайлангийн тайлант үеэс өөр тохиолдолд дараах мэдээллийг тодруулах эсэхийг харгалзан үзвэл зохино:

- (a) Уг хамаарах үйлчилгээнүүд,
- (б) Холбогдох тайлагналын үе (үеүд), ба
- (в) Ийм өөр байдлын талаархи тайлбар.

Санхүүгийн тайлангаас тусдаа байх тохиолдол дахь тодруулга

67. НЗСТ дахь үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн байршлыг доорх 72-75-р параграфт авч хэлэлцсэн. Тухайн санхүүгийн тайланг агуулсан НЗСТ-гаас уг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тусдаа толилуулдаг тохиолдолд дараах мэдээллийг толилуулах хэрэгтэй:

- (a) Байгууллагын нэр;
- (б) Уг байгууллага нь хяналт тавигч байгууллага бол тэрхүү тайлагнагч байгууллагын хяналтанд буй байгууллагуудын группын тайлбар тодорхойлолт;
- (в) Уг байгууллага нь хяналтанд буй байгууллага бол түүний хяналт тавигч байгууллагын тодорхойлолт;
- (г) Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэлд хамаарах тайлангийн өдөр ба тайлагналын үе;
- (д) Уг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн хамаарах санхүүгийн тайлан ба уг санхүүгийн тайланг олж тогтооход хэрэглэгчдэд шаардлагатай хангалттай мэдээлэл;
- (е) УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-д тодорхойлсон толилуулгын валют; ба
- (ж) Ашигласан бүхэлчлэлийн түвшин.

68. Санхүүгийн тайланг агуулсан НЗСТ-д үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг толилуулдаг тохиолдолд уг мэдээллийг хэрхэн толилуулахыг холбогдох УСНББОУС-аар тогтоодог.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

### Хүүрнэсэн хэлэлцүүлэг ба шинжилгээ

69. Байгууллага нь өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн талаархи хүүрнэсэн хэлэлцүүлэг ба шинжилгээг тодруулах хэрэгтэй. Хүүрнэсэн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь тухайн байгууллагын зүгээс дараах зүйлсийн талаар гүнзгий ойлголт олж авах боломжийг хэрэглэгчдэд олгосноор уг тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн нэмэлт гүйцээлт болдог:
- (a) Онцлон дурдах хэрэгтэй гэж уг байгууллагын үзэж буй үйлчилгээний гүйцэтгэлийн төлөв байдал; ба
  - (б) Үйлчилгээний гүйцэтгэлийн биелэлтэд тухайн тайлант үеийн туршид нөлөөлсөн хүчин зүйлс.
70. Хүүрнэсэн хэлэлцүүлэг ба шинжилгээ нь тухайн байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн талаархи товч тойм мэдээгээр хангадаг бөгөөд энэ мэдээ нь:
- (a) Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын биелэлтийн хэмжээг авч хэлэлцдэг;
  - (б) Уг толилуулсан мэдээллийн тэнцвэртэй талаар хангадаг, энэ нь тухайн байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн эерэг ба сөрөг төлөв байдлуудын аль алиныг хамарсан байдаг; ба
  - (в) Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн үр ашиг ба үр дүнгийн талаархи хэрэглэгчдийн үнэлгээнд туслалцаа үзүүлдэг.
71. Хүүрнэсэн хэлэлцүүлэг ба шинжилгээнд тусган оруулж болох мэдээллийн төрлүүдийг энэхүү СБПУ 3-ын дагалдах Хэрэгжүүлэлтийн Жишээнд үлгэрчлэн харуулсан.

### Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн байршил

72. Байгууллага нь үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг дараах хоёр хувилбарын аль нэгээр толилуулж болно:
- (a) Санхүүгийн тайланг агуулсан НЗСТ-гийн нэг хэсэг байдлаар; эсвэл
  - (б) Тусдаа гаргасан НЗСТ-д.
73. Энэхүү шийдвэрийг гаргахдаа дараах хүчин зүйлсийг харгалзан үзвэл зохино:
- (a) Санхүүгийн тайлан дахь мэдээллийн, үүн дотроо төсөв ба бодит гүйцэтгэлийн зэрэгцүүлэлтийн талаархи мэдээллийн хүрээнд уг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг нягталж шалгах шаардлагатай хэмжээ;
  - (б) Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тухайн санхүүгийн тайланг агуулсан уг НЗСТ-д эсвэл тусдаа НЗСТ-д тусгах эсэх нь

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага ба чанарын шинжүүдийг сайжруулах эсэх;

- (в) Мэдээллийн нийтлэг хязгаарлалтуудын мөрдөлт, үүн дотроо (хэрэв байгаа) холбогдох нэмэлт өртөг зардлыг тухайн санхүүгийн тайлан зөвтгөн баталдагтай адилаар уг мэдээллийг тэрхүү НЗСТ-д тусган оруулснаар үр өгөөжтэй байх эсэх; ба
- (г) Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тухайн санхүүгийн тайлантай адилаар уг НЗСТ-д, эсвэл тусдаа НЗСТ-д тусган оруулах хэрэгтэй эсэхийг заасан байж болох улс орны тусгайлсан шаардлагууд.

74. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллээр хангахын үндсэн зорилго бол дараах зүйлс байх эсэх нь дээрх 73-р параграфын (а)-д дурдсан асуудлын хувьд уг шийдвэрийн чухал хүчин зүйл байх магадлалтай юм:

- (а) Төсвийн хуваарилалттай зэрэгцүүлэн харуулсан санхүүгийн тайлантай уг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагналыг холбох нь үнэ цэнэтэй байх магадлалтай тохиолдолд үйлчилгээ үзүүлэхэд зориулсан нөөцийн хуваарилалтын шийдвэрийн талаархи үнэлгээг мэдээлэх; эсвэл
- (б) Бодлого буюу стратегийн талаархи мэдээлэлтэй уг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагналыг холбох нь үнэ цэнэтэй байх магадлалтай тохиолдолд бодлогын болон стратегийн шийдвэрийн хувьд үнэлгээг мэдээлэх.

75. Байгууллага нь өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тухайн санхүүгийн тайлангаас тусдаа НЗСТ-д толилуулах сонголт хийсэн бол уг тусдаа НЗСТ-г цаг хугацаанд нь бэлтгэн гаргаж байх хэрэгтэй. Цаг хугацаанд нь гэдгийг тухайн санхүүгийн тайлантай ижил хугацаанд гаргаснаар, хэрэв ижил биш бол уг санхүүгийн тайлангийн гаргалттай ойролцоо хугацаанд гаргаснаар ихэвчлэн илэрхийлдэг.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

76. НЗСТ дахь үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн зохион байгуулалт нь хэрэглэгчдэд дараах боломж олгодог байвал зохино:

- (а) Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийг, үүн дотроо түүний үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын биелэлтийг ойлгох;
- (б) Байгууллагын үйлчилгээний үр ашиг ба үр дүнтэй байдлыг үнэлэх; ба
- (в) Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгод ашиглах.

77. Тайлагнасан мэдээлэл ба дараах зүйлсийн хоорондох харилцан холбоог ойлгомжтой тодорхой байхуйцаар уг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг зохион байгуулах хэрэгтэй:

- (а) Тайлагнасан мэдээллийн суурийн талаархи тодруулга, ба

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

(б) Хүүрнэсэн хэлэлцүүлэг ба шинжилгээ.

78. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг зохион байгуулах нэг арга зам нь мэдээллийг хүснэгт буюу тайлан хэлбэрээр зохион байгуулах “үйлчилгээний гүйцэтгэлийн тайлан” юм. Толилуулсан гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь олон үйлчилгээний талаар тайлагнасан тоон хэмжүүр эсвэл чанарын хэмжүүр байх тохиолдолд үйлчилгээний гүйцэтгэлийн тайлан нь ойлгомжтой ба зэрэгцүүлэгдэх байдлыг сайжруулдаг.
79. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг хүүрнэсэн эсвэл тохиолдлын судалгаа хэлбэрээр толилуулдаг тохиолдолд хүснэгтэн арга хэлбэр нь тохиромжтой байх магадлал багатай юм. Тохиолдлын судалгаа, нэг буюу хэд хэдэн хүснэгт болон тайлангийн холимог хэлбэр нь зарим үед тохиромжтой байдаг.
80. Дараах зүйлсийн хоорондох тэнцвэрийг хангахын тулд байгууллага нь тайлагналын хэд хэдэн түвшинг ашиглаж болно:
- (а) Ойлгоход хангалттай товч тодорхой байх; ба
  - (б) Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилт нэг бүртэй холбоотой олон төлөв байдлуудын талаархи хангалттай дэлгэрэнгүй мэдээллээр хангах.
81. Үйлчилгээний талбаруудыг тухайлбал, хоёр буюу хэд хэдэн бие даасан үйлчилгээнд салган задалж болох тохиолдолд тайлагналын хэд хэдэн түвшинг ашиглах нь арай дээд түвшинд товч тодорхой тайлагнах, харин доод түвшинд илүү дэлгэрэнгүй тайлагнах буюу тодруулах боломж олгодог.
82. Байгууллагын сегментүүдийн тодорхойлолтонд УСНББОУС 18, *Сегментийн Тайлагнал*-ыг мөрддөг. Энэ Стандарт нь үйлчилгээний сегментүүдийг тайлбарлан тодорхойлж, санхүүгийн тайлагналын зорилгоор үйлчилгээг сегментүүдэд бүлэглэхдээ харгалзан үзвэл зохих хүчин зүйлсийг тогтоодог.

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь СБПУ 3-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Оршил

*Төслийн санаачилга, Зөвлөлдөх Баримт Бичиг, Удирдамж боловсруулах шийдвэр*

ДҮ1. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагналын талаархи УСНББОУСЗ-ийн төсөл нь сонгон авсан улс орнууд, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн тайлагналд (буюу үүнтэй адилтгах зүйлсэд) зориулсан үндэсний стандартууд, заавар удирдамж, зохицуулалтын шаардлагуудыг нягталж шалгаснаар эхэлсэн. Үйлчилгээний гүйцэтгэлийн тайлагналын ижил үзэл баримтлалтай хоёр улс ч байгаагүй боловч тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн хувьд ижил төсөөтэй зүйлс байсан. Эдгээр ижил төсөөтэй зүйлс болон нийтлэг ашигладаг нэр томъёог харгалзан үзсэнээр *Үйлчилгээний Гүйцэтгэлийн Мэдээллийн Тайлагнал* гэсэн Зөвлөлдөх Баримт Бичиг (ЗББ)-ийн үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд үүнийг 2011 онд гаргасан. ЗББ нь үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагналд зориулсан зарчимд суурилсан үзэл баримтлал болон стандарт нэр томъёог санал болгосон.

*Санал болгосон практик удирдамжийн боловсруулалт*

ДҮ2. Санхүүгийн тайланд тусгадагаас бусад нэмэлт мэдээллийг Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ) боловсруулах замаар одоо авч үзэх хэрэгтэй гэж УСНББОУСЗ нь 2013 онд шийдвэрлэсэн. Иймээс үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагналд зориулсан СБПУ-ийн төсөл буюу СТ 54, *Үйлчилгээний Гүйцэтгэлийн Мэдээллийн Тайлагнал*-ыг боловсруулсан. ЗББ-д зориулан боловсруулсан ба уг ЗББ-т ирүүлсэн хариултуудын нягтлах шалгалт, түүнчлэн СТ 54-т ирүүлсэн хариултуудын дараагийн нягтлах шалгалтын явцад УСНББОУСЗ-ийн шийдвэрээр хянан засварласан үйлчилгээний гүйцэтгэлийн тайлагналын үзэл баримтлалд энэхүү СБПУ нь үндэслэсэн. Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал (Онолын Үзэл Баримтлал)-аар энэхүү СБПУ-ийг дэмжсэн.

### **СБПУ-ийн ерөнхий хандлага-Шийдвэр ба хамгийн наад захын шинж тэмдгүүдийн талаархи удирдамж**

ДҮ3. Энэхүү СБПУ-ийг боловсруулах үедээ түүний ерөнхий хандлага нь дараах зүйлсийг гүйцэтгэхэд чиглэх хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн:

- (a) Сайн практик ба шаардлагуудын талаархи заавар удирдамжаар хангах уг СБПУ-ийн үүрэгтэй нийцсэн, үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн хамгийн наад захын шинж чанаруудыг тогтоох; эсвэл

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

- (б) Тайлан бэлтгэгчдийн гаргах шаардлагатай шийдвэрүүд болон тэдгээр шийдвэрийн талаархи удирдамжийг тодорхойлсон үзэл баримтлалыг уг ЗББ дэх үзэл баримтлалын хандлага болон СБПУ-ийн чиг үүрэгтэй нийцүүлэн удирдамж байдлаар тогтоох.

- ДҮ4. Үйлчилгээний болон тайлагналын хүрээний олон янз байдлыг харгалзан УСНББОУСЗ нь энэхүү СБПУ-аар үйлчилгээний гүйцэтгэлийн тайлагналыг стандартчлахыг эрмэлзэх бус, харин зарчмуудын биелэлтэнд, мөн түүнчлэн толилуулвал зохих үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн гол төрлүүдэд анхаарал хандуулах хэрэгтэй гэж шийдвэрлэсэн. Ямар төрлийн мэдээлэл толилуулах хэрэгтэй эсэх талаар заавар удирдамж шаардлагатай гэсэн үндэслэлээр энэ хандлагыг баримталсан бөгөөд өргөн хүрээтэй мэдээллийн ангиллуудыг тодорхойлох боломжтой байдаг. Жишээлбэл; үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын талаархи мэдээлэл нь үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнадаг бүх байгууллагад хамааралтай юм.
- ДҮ5. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагналд зориулсан СБПУ-ийг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь дэлхий дахины олон төрлийн үйлчилгээ, үйлчилгээний гүйцэтгэлийн өөр өөр зорилтууд, хариуцлагын болон шийдвэр гаргалтын янз бүрийн хүрээнд мөрдөхөд ач холбогдолтой байх тийм удирдамж боловсруулахад нэлээд төвөгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Ерөнхийдөө, үйлчилгээний гүйцэтгэлийн тайлагналын чанар нь нэг талаас, уг үзүүлсэн үйлчилгээнээс үүсэх мэдээллийн тодорхой хэрэгцээ шаардлагыг хангах хэмжээнээс, нөгөө талаас үйлчилгээг үзүүлэх нөхцөл байдлаас хамаардаг. Жишээлбэл; чухал зорилтод чиглэсэн явц өрнөлд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийн талаар өгүүлэх тайлан нь тухайн хангасан нөөцөөр үзүүлсэн үйлчилгээний тооцоог харуулах тайлангаас эрс өөр байж болох юм. УСНББОУСЗ нь эдгээр асуудлыг авч үзсэн бөгөөд хамгийн наад захын стандартуудыг тогтоох СБПУ-ыг биш, харин тайлан бэлтгэгч нарын гаргах шаардлагатай шийдвэрийг тодорхойлох, иймээс тэрхүү шийдвэрийг хэрхэн гаргах талаархи удирдамжаар хангах тийм СБПУ боловсруулах нь хамгийн их ач холбогдолтой гэсэн байр суурьтай байсан.
- ДҮ6. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагналд мөрдөх зарчмууд нь дэлхий дахинд оршин буй янз бүрийн үйлчилгээ болон үйлчилгээ үзүүлэх өөр өөр нөхцөл байдалд тохиромжтой биш байж болох дэлхий нийтийг хамарсан шаардлагууд тогтоохыг эрмэлзэхгүйгээр, харин ач тустай удирдамжаар хангах байр суурийг УСНББОУСЗ баримталсан. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь хөгжиж буй талбар тул СБПУ нь хэт зааварчилсан биш байвал зохино гэсэн үг юм.
- ДҮ7. Шаардлагуудыг тогтоохгүй гэж тунхагласан СБПУ ба уг СБПУ-ийн даган мөрдөлт нь түүний бүх шаардлагуудын даган мөрдөлтийг агуулна гэж заасан СТ-ийн 5-р параграф хоорондоо илт зөрчилдөж байгааг уг СТ-д хариулт ирүүлсэн зарим хүмүүс шүүмжилсэн. УСНББОУСЗ нь уг параграф дахь “шаардлагуудын даган мөрдөлт” гэсэн хэллэгийг “зарчмуудын мөрдөлт” гэж өөрчлөхөөр шийдвэрлэсэн. Энэ нь хоёр үндэслэлтэй юм.

Нэгдүгээрт, үйлчилгээний гүйцэтгэлийн ямар мэдээллийг тайлагнах эсэх талаархи өөрийн шийдвэрийн удирдамж болгон байгууллагуудын ашиглах зарчмуудыг уг СБПУ-аар тогтоодог. Хоёрдугаарт, “мөрдөх” гэсэн санааг уг параграфт ашигласан хэвээр байгаа боловч энэ нь санал болгосон удирдамж болохын хувьд тэрхүү СБПУ-ийн үүрэгтэй нийцнэ гэж УСНББОУСЗ үзсэн. Тухайн байгууллага УСНББОУС-ыг даган мөрдөхөд сөргөөр нөлөөлөхгүйгээр уг СБПУ-ийг бүхэлд нь мөрдөхгүй байхыг байгууллагуудад зөвшөөрснөөр СБПУ-ийн шинж төрлийг заавар удирдамж байдлаар тогтоосон. Тайлан бэлтгэгч нар (буюу улс орнууд) нь мөн уг СБПУ-ийн зарим хэсгийг дагаж мөрдөх, тухайлбал, бүрэн даган мөрдөлтөд аажмаар шилжих сонголт хийж болох бөгөөд ба ингэж шилжсэн үед даган мөрдсөн гэж мэдэгдэж болох юм. Хэдий тийм боловч СБПУ-ийн тодорхой агуулга нь сайн практикыг тогтоосон цогц зарчмуудыг агуулсан байдаг. Харгалзан үзэж буй сэдвээс хамааран СБПУ нь УСНББОУС-тай харьцуулахад илүү уян хатан мөрдөлтийн нөхцлийг бас агуулсан байж болно. Тухайлбал; энэ СБПУ нь толилуулгын хувьд сонголтуудыг оруулсан бөгөөд ямар мэдээллийг толилуулах талаархи тухайн тайлан бэлтгэгчдийн шийдвэрийн хувьд удирдамж болох зарчмуудыг тусгасан.

## Цар хүрээ

ДҮ8. Энэ СБПУ-ийг гаргах үед УСНББОУСЗ нь түүнийг [Улсын Үйлдвэрийн Газрууд (УҮГ)]-д (2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргаснаас хойш ийм дөрвөлжин хаалтанд тусгасан нэр томъёог цаашид ашиглахаа больсон) мөрдөх хэрэгтэй эсэхийг авч үзсэн. УҮГ нь үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тэдгээр үйлчилгээний хувьд үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнаж болно гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч УСНББОУСЗ нь энэхүү СБПУ-ийг УҮГ-аас бусад, улсын секторын бүх байгууллагад мөрдүүлэхээр шийдвэрлэсэн. СБПУ-ийг гаргах үед энэ нь *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил*-той нийцэж байсан. УСНББОУСЗ нь УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудын ашиглах нягтлан бодох бүртгэлийн стандартууд болон бусад хэвлэл бүтээлийг боловсруулдаг гэдгийг тус Оршилд заасан байдаг. Цар хүрээнд ингэж хамруулаагүй байдлыг УҮГ-ууд нь уг удирдамжийг мөрдөж болохгүй гэсэн утгаар ойлгох хэрэггүй бөгөөд энэхүү удирдамжийг УҮГ мөрдөхөд ямар нэг хориг саад байхгүй юм.

ДҮ9. Хяналт тавигч байгууллага нь энэ СБПУ-д заасан зөвлөмжийн дагуу үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллээ тайлагнадаг тохиолдолд түүний хяналтанд буй нэг буюу хэд хэдэн УҮГ-уудын үзүүлсэн үйлчилгээний талаархи мэдээллээр тус хяналт тавигч байгууллага хангаж болно гэдгийг УСНББОУСЗ нь дээрх дүгнэлтийг гаргахдаа онцлон тэмдэглэсэн. Хэдийгээр УҮГ-ын өөрийн тайлагнал нь энэ СБПУ-ийн цар хүрээнд хамаардаггүй боловч түүний хяналт тавигч байгууллага нь СБПУ-ийг даган мөрдсөн гэж илэрхийлсэн бол тус УҮГ-ын үйлчилгээний талаар тэрхүү хяналт тавигч байгууллагын тайлагнасан мэдээлэл нь энэ СБПУ-ийн шаардлагуудыг баримталсан байх ёстой гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн.

ДҮ10. Улсын секторын байгууллагуудын үйлчилгээний гүйцэтгэлийн талаархи мэдээллийн тайлагналын хувьд угаасаа өргөн хүрээний шаардлагуудтай, тэдгээр шаардлагууд нь мэдээлэлд мөрдөхөөр тус СБПУ-д заасан зарчмын хандлагаас илүү байж болох тийм улс орон дахь байгууллагууд нь энэ СБПУ-ийг мөрдөх хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Ийм нөхцөл байдалд байгууллага нь тухайн улс орны шаардлагуудыг ханган биелүүлэх хэрэгтэй гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Хэдийгээр СБПУ нь дэлгэрэнгүй нарийвчилсан ба тусгайлсан шаардлагуудыг тогтоодоггүй боловч энэ нь үндэсний буюу бусад шаардлагуудын дагуу угаасаа тайлагнадаг хэмжээнээс бага түвшнээр тайлагнахыг дэмжинэ гэсэн утга илэрхийлэхгүй, нөгөө талаас үүнийг илүү өргөн хүрээний тайлагналтай зөрчилдөнө гэж үзэж болохгүй юм. Энэ СБПУ ба үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн талаархи улс орны шаардлагуудын хоорондох уялдаа холбоог тус СБПУ-ийн 6–7-р параграфт авч үзсэн бөгөөд нэмэлт мэдээлэл толилуулах, түүнчлэн СБПУ-ийн удирдамжаас гадна улс орны илүү дэлгэрэнгүй шаардлагуудыг даган мөрдөхийг энэ СБПУ-аар хориглохгүй гэдгийг тайлбарласан. Энэ асуудлыг СБПУ-д зохих ёсоор авч үзсэн бөгөөд үйлчилгээний гүйцэтгэлийн талаархи мэдээллийн тайлагналын хувьд угаасаа өргөн хүрээний шаардлагуудтай тийм улс орон дахь байгууллагуудад энэ СБПУ-ийг мөрдөх боломжтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

### **Нэр томъёоны тодорхойлолт**

ДҮ11. Хэдийгээр байгууллагууд нь зарим нэр томъёог тууштай хэрэглэдэг боловч тийм олон байгууллага өөрийн ашиглаж буй зарим буюу бүх нэр томъёог тодорхойлоогүй байдаг гэдгийг УСНББОУСЗ нь үйлчилгээний гүйцэтгэлийн стандартчилсан нэр томъёо шаардлагатай гэсэн өөрийн байр сууринд хүрэхдээ тэмдэглэсэн. Түүнчлэн, нэг ижил нэр томъёо нь өөр өөр улс оронд янз бүрийн утгатай байдаг. Энэ үндэслэлээр УСНББОУСЗ нь НЗСТ-д байгууллагуудын тайлагнадаг үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн ойлгомжтой ба зэрэгцүүлэгдэх байдлыг дэмжихэд үйлчилгээний гүйцэтгэлийн стандартчилсан нэр томъёо зайлшгүй шаардлагатай гэж дүгнэсэн.

ДҮ12. Сайтар бодож тунгаасан ба тодорхой илэрхийлсэн хандлага, үйлчилгээний гүйцэтгэлийн тайлагналын өргөн туршлагыг харгалзаж, улс орнуудад угаасаа хэрэглэж заншсан нэр томъёонд аль болох үндэслэх замаар УСНББОУСЗ нь энэ СБПУ дахь тодорхойлсон нэр томъёонуудыг боловсруулсан.

ДҮ13. ЗББ ба СТ-д ирүүлсэн хариултуудын нягтлах шалгалт, СБПУ-ийн дараагийн хөгжүүлэлтийн явцад УСНББОУСЗ нь үр дүнтэй байдлын үзүүлэлтийн тодорхойлолтыг хянан засварласан. ЗББ дэх тодорхойлолт нь дараах байдалтай байсан: “Үр дүнтэй байдлын үзүүлэлтүүд нь гарц ба үр дүнгийн хоорондох харилцан хамаарлын хэмжүүр юм.” Энэ нь гарц ба үр дүнгийн хоорондох харилцан хамаарлыг хэмжихэд харьцангуй хялбар гэсэн утгатай байна. Гарц ба үр дүнгийн хоорондох харилцан хамаарал нь олон нөхцөл байдалд уг анхны тодорхойлолтод илэрхийлсэн энгийн



хялбар хамаарлаас илүү нарийн цогц байх магадлалтай гэж УСНББОУСЗ нь цаашид судлан үзсэний дараа дүгнэсэн. Түүнчлэн, үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудаа биелүүлэхэд тухайн байгууллагын хүрсэн амжилтын түвшин гэвэл үр дүнтэй байдал нь илүү ойлгомжтой болно гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс үр дүнтэй байдлын үзүүлэлтүүд нь байгууллага өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудад хүрсэн хэмжээг харуулдаг гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ14. ЗББ ба СТ 54-ийн боловсруулалт, түүнчлэн СТ 54-т ирүүлсэн хариултуудын дараагийн нягтлах шалгалтын явцад УСНББОУСЗ нь уг СБПУ-ийн тодорхойлсон цогц нэр томъёонд “хэмнэлтийн үзүүлэлтүүд”-ийг тусган оруулах эсэхийг харгалзан үзсэн. СБПУ-д тодорхойлсон бусад нэр томъёог харгалзан үзэхэд уг нэр томъёо нь будилахад хүргэх ба онцын шаардлагагүй байсан учраас УСНББОУСЗ-ийн гишүүд нь хэмнэлтийн үзүүлэлтүүдийг оруулахгүй байхаар шийдвэрлэсэн. Энэ СБПУ-д ойлгомжтой тодорхойлсон орц болон үр ашгаар илэрхийлэх утга санаанд “хэмнэлтийн үзүүлэлтүүд” нь ямар нэг зүйлийг нэмж илэрхийлэхгүй юм. Тухайн улс үндэстэн нь “хэмнэлт” гэдэг үгээр ямар утга илэрхийлдэг байдгаас үл хамааран үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн сонголтын хувьд энэ СБПУ-аар баримтлах арга хандлага нь “хэмнэлт”-ийг хянан үнэлэх боломжийг улс орнуудад олгосон гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Тухайлбал; энэ СБПУ нь өртөг, бусад орц, үр ашгийн талаархи мэдээллийн толилуулгыг сайшаан дэмждэг.

ДҮ15. Хэмнэлт нь үйлчилгээний гүйцэтгэл тайлагналын хүрээнд нийтлэг хэрэглэгддэг нэр томъёо юм. Гэвч өөр өөр улс оронд хэмнэлт нь янз бүрийн утгатай байдаг. Зарим улс орны хувьд, хэмнэлт нь үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээ ба/буюу чанарт үзүүлэх нөлөөг харгалзахгүйгээр тухайн үйлчилгээний нийлүүлэлтийн хувьд арай бага өртөг зардалтай байх гэсэн утгыг илэрхийлдэг. Энэхүү эхний байр суурьт дурдсан ойлголт нь бодит хэмнэлт биш, хэдийгээр өртөг зардал буурсан боловч үйлчилгээний тоо хэмжээ ба/буюу чанарт сөргөөр нөлөөлж болох нөхцөл байдлыг илэрхийлэхдээ “хэмнэлт” гэдэг үг ашиглах нь НЗСТ-ийн хэрэглэгчдийг төөрөгдөлд хүргэнэ гэж зарим улс орнууд үздэг. Өртөг болон бусад орцыг бууруулсан боловч үйлчилгээний нийлүүлэлтийг хэвээр хадгалсан эсвэл нэмэгдүүлсэн зөвхөн тийм тохиолдолд хэмнэлт бий болно гэсэн хоёр дахь байр суурь байдаг. “Хэмнэлт”-ийн талаархи хоёр дахь байр суурь нь энэ СБПУ-д дурдсан, “үр ашиг”-ийн тодорхойлолттой нийцэж байна. Үнэн хэрэгтээ, “хэмнэлт” нэр томъёо нь будлиан үүсгэх ба үр ашиг гэсэн ойлголттой давхцана гэсэн үндэслэлээр уг нэр томъёог ашигладаггүй гурав дахь бүлэг буюу улс үндэстнүүд байдаг. Иймээс энэ СБПУ-д “хэмнэлтийн үзүүлэлтүүд”-ийг тодорхойлоогүй бөгөөд “хэмнэлт” гэсэн нэр томъёог ашиглаагүй.

### **Тайлагнагч байгууллага**

ДҮ16. НЗСТ-гийн хэрэглэгчид нь тухайн байгууллагын үйлчилгээний нийлүүлэлт ба нөөцийн ашиглалтын хувьд түүнийг хариуцлагатай байлгаж, мөн уг байгууллагад нөлөөлөх шийдвэрийг гаргадаг тул үйлчилгээний

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

гүйцэтгэлийн мэдээлэл нь хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлдэг байвал зохино. Иймээс УСНББОУСЗ-ийн гишүүдийн олонхи нь санхүүгийн тайланг бэлтгэж буй тухайн тайлагнагч байгууллагын хувьд үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг бэлтгэх хэрэгтэй гэж үзсэн. СБПУ 1 ба 2-ын (СБПУ 1-ийн 14-р параграф, СБПУ 2-ын 4-р параграфыг үзнэ үү) хамрах хүрээтэй нийцүүлэхийн тулд СБПУ 3-ын хэллэг нь тайлагнагч байгууллага биш, харин “тайлагналын хил хязгаар” гэсэн үгэнд голлон чиглэсэн байдаг. СБПУ-ийн хариуцлагын болон шийдвэр гаргалтын гол анхаарах зүйл нь бие биедээ нөлөөлж болох боловч хяналт тавих чадваргүй нийлүүлэлтийн суваг, бие даасан байгууллагуудын сүлжээ буюу бусад нэгдэлд үүнийг мөрдөхөд зориулагдаагүй гэдгийг УСНББОУСЗ нь энэхүү дүгнэлтийг гаргах үедээ бас тэмдэглэсэн.

ДҮ17. Ерөнхий хяналтанд байдаггүй байгууллагуудын группыг агуулсан хөтөлбөр буюу бодлогын тайлагналд, өөрөөр хэлбэл “хил дамнасан” тайлагналд зориулсан заавар удирдамжаар энэхүү СБПУ бас хангах хэрэгтэй гэдгийг уг СТ-д хариулт ирүүлсэн зарим хүмүүс илэрхийлсэн. Санхүүгийн тайлангийн тайлагнагч байгууллагатай ижил тайлагнагч байгууллагын хил хязгаарт мөрдөх үйлчилгээний гүйцэтгэлийн тайлагнал ба хил-дамнасан тайлагналын цар хүрээгээр хангах уян хатан тайлагналын хил хягаарын хоорондох тэнцвэрийг хангах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Санхүүгийн тайлангийн тайлагнагч байгууллагатай ижил тайлагнагч байгууллагад голлон чиглэх нь үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн цуглуулалт ба уг мэдээллийг тухайн байгууллагын санхүүгийн тайлан дахь санхүүгийн мэдээлэлтэй нэгтгэхэд мөн туслалцаа үзүүлэхийн зэрэгцээгээр хяналтын шугамыг баримтлах, зохион байгуулалтад чиглэсэн хариуцлагыг сайжруулах ач тустай байдаг. Гэвч хөтөлбөр буюу бодлогыг хариуцах бие даасан байгууллага байхгүй бөгөөд уг хөтөлбөр буюу бодлоготой холбоотой үйлчилгээний гүйцэтгэлийг илүү сайн тайлбарлах мэдээллээр хангах, тухайн хөтөлбөр буюу бодлоготой нийцсэн хил-дамнасан тайлагналыг шаардах тийм тохиолдол гардаг. Иймээс УСНББОУСЗ нь тухайн үр дүнд (үр дүнгүүдэд) хувь нэмрээ оруулах “хөтөлбөр” буюу “цогц үйл ажиллагаа”-ны талаархи хил дамнасан тайлагналд зориулсан удирдамжийг мөн тусган оруулахын тулд энэхүү СБПУ-ийн цар хүрээг өргөжүүлэх эсэхийг харгалзан үзсэн. Гэвч энэ СБПУ нь санхүүгийн тайлангийн тайлагнагч байгууллагатай ижил тайлагнагч байгууллагын тайлагналд голлон чиглэсэн хэвээр байх хэрэгтэй гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн. Улс үндэстнүүд нь энэхүү СБПУ-ийн зарчмууд болон удирдамжийг хил дамнасан тайлагналд тохируулан мөрдөхөд энэ нь саад учруулахгүй юм.

ДҮ18. Хяналт тавигч байгууллагууд нь өөрсдийн хяналтанд буй байгууллагуудын үзүүлсэн бүх үйлчилгээг тайлагнах шаардлагатай эсэх талаар уг ЗББ болон СТ-д хариулт ирүүлсэн хүмүүсийн илэрхийлсэн санаа зовж буй зүйлсийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. Энэ нь чанарын шинжүүдийг хангах, түүнчлэн хариуцлагын болон шийдвэр гаргалтын хувьд хэрэглэгчдийн үнэлгээг дэмжихийн тулд мэдээллийг хэт дэлгэрэнгүй ба нүсэр болгоход хүргэж болох юм. Уг санаа зовж буй асуудлыг авч үзэхийн тулд УСНББОУСЗ нь энэхүү СБПУ-д нэмэлт тайлбар оруулахаар

шийдвэрлэсэн. Иймээс хяналт тавигч байгууллагууд нь хяналтанд буй байгууллагуудынхаа үзүүлсэн бүх үйлчилгээг нэгтгэн нийлүүлэхийг эрмэлзэхийн оронд, өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын биелэлтийг тайлагнах хэрэгтэй гэж энэхүү СБПУ-д заасан.

### **Жилийн тайлагнал ба тайлагналын үе**

ДҮ19. Үр дүн, гарц, орцоор илэрхийлсэн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд нь биелүүлэхэд нэг жилээс урт хугацаа шаардаж болох тохиолдолд үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг жил бүр тайлагнах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Хэрэглэгчид нь өөрийн хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд шаардлагатай мэдээлэлтэй гэдгийг ханган магадлах нь чухал ач холбогдолтой учраас үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг жил бүр тайлагнах хэрэгтэй гэж УСНББОУСЗ-ийн олонхи гишүүд үзсэн. Олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын оршин байдлыг авч үзэхийн тулд байгууллагууд нь тэрхүү олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудад чиглэсэн өөрсдийн явц өрнөлийн талаархи мэдээллийг тодруулахыг энэхүү СБПУ-аар дэмжих хэрэгтэй гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн. СТ-д ирүүлсэн хариултууд нь жил тутмын тайлагналыг ерөнхийдөө хүчтэй дэмжиж байсныг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага нь өөр тайлант үеийг шаардаж байхаас бусад тохиолдолд үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг жил бүр тайлагнах ба тухайн санхүүгийн тайлангийн тайлант үетэй ижил тайлант үеийг ашиглах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ баталгаажуулсан.

#### *Илүү ойр давтамжтай тайлагнах цар хүрээ*

ДҮ20. Байгууллагууд нь нэг жилээс богино хугацаагаар тайлагнахыг СТ-өөр зөвшөөрөхгүй байна гэсэн шүүмжлэлийг уг СТ-д хариулт ирүүлсэн хүмүүс илэрхийлсэн. УСНББОУСЗ нь илүү ойр давтамжтай тайлагналын цар хүрээг дэмжсэн хүмүүстэй санал нэг байсан бөгөөд илүү ойр давтамжтай тайлагнах нь ил тод ба хариуцлагатай байдлыг сайжруулах магадлалтай гэдгийг тэмдэглэсэн. Хариулт ирүүлсэн нэг хүний дурдсанчлан, илүү ойр давтамжтай тайлагнал нь “төрийн бодлогын хянан үнэлсэн эрхэм зорилгод оролцогч бүх талуудын хоорондох менежментийн хэлэлцүүлгийг мөн сайшаан дэмжих ба төрийн менежерийн хариуцлагыг нэмэгдүүлснээр удирдлагын үйл явцыг сайжруулах” юм. Иймээс УСНББОУСЗ нь илүү ойр давтамжтай тайлагнах боломж олгох ба тайлагналын давтамжийг тогтоохын тулд УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Топилуулга*-д ашигласан хэллэгтэй ижил хэллэг болох “наад зах нь жил бүр тайлагнах хэрэгтэй” гэсэн хэллэгийг ашиглахаар шийдвэрлэсэн.

#### *Олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын тайлагнал*

ДҮ21. Жил тутмын тайлагнал нь үр дүнгийн тайлагналд сөрөг нөлөөтэй байж болно, үүн дотроо жил тутмын тайлагнал нь үр дүнгээ байгууллагууд тайлагнах хэмжээг бууруулах зориудын бус үр дагавартай байх боломжтой гэж уг СТ-д хариулт ирүүлсэн зарим хүмүүсийн санаа зовж буй асуудлыг

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

УСНББОУСЗ харгалзан үзсэн. Зарим үр дүнгийн хувьд жил тутмын хэмжилт хийхэд хэт өндөр өртөгтэй бөгөөд үр дүнг биелүүлэхэд чиглэсэн явц өрнөлийг харуулах хэмжиж болохуйц өөрчлөлт нь хоёр буюу хэд хэдэн жилийн хугацаанд илэрдэггүй гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Ийм нөхцөл байдалд жил тутмын тайлагнал нь төөрөгдөлд хүргэж болох юм гэж хариулт ирүүлсэн нэг хүн санал гаргасан. Энэ асуудал нь зөвхөн үр дүнд чиглэсэн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудаар хязгаарлагдахгүй бөгөөд гарц, орцын тайлагналд бас үүсэж болох юм. Уг асуудлыг зохицуулахын тулд энэ СБПУ нь төлөөлөх хэмжүүр ашиглах талаархи тодорхой хүрээг тусган оруулсан бөгөөд үр дүн буюу олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн бусад төрлийн зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн явц өрнөлийн шинж үзүүлэлт байдлаар гарц, орцыг байгууллагууд тайлагнах тийм цар хүрээг бүрдүүлж өгсөн.

*Санхүүгийн тайлангийн хугацаатай ижил хугацаанд гаргасан үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл*

ДҮ22. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тухайн санхүүгийн тайлангийн хугацаатай ижил хугацаанд гаргах хэрэгтэй гэж энэ СБПУ-д заах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Санхүүгийн тайлангийн хугацаатай ижил хугацаагаар гаргах нь цаг хугацаандаа байхад дэмжлэг үзүүлэх боловч ингэж бэлтгэхэд зарим байгууллагын хувьд маш төвөгтэй байж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Хэдийгээр үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн санхүүгийн тайлантай ижил хугацаанд тайлагнах нь зохистой гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч УСНББОУСЗ нь үүнийг зайлшгүй шаардлага болгон энэхүү СБПУ-д заах хэрэггүй гэж шийдвэрлэсэн.

*Өөр тайлант үе бүхий хяналт тавигч байгууллага ба хяналтанд буй байгууллагууд*

ДҮ23. Хяналт тавигч байгууллага нь түүний тайлант үеэс өөр тайлант үе бүхий тэдгээр хяналтанд буй байгууллагуудын үзүүлсэн үйлчилгээний талаархи мэдээллийг тусган оруулах нөхцөл байдлуудыг УСНББОУСЗ авч үзсэн. Тухайн тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн бүх мэдээлэл нь нэг ижил тайлант үеийг хамарч байвал хамгийн зохистой юм. Гэвч хяналт тавигч байгууллагын тайлант үетэй мэдээллийг нийцүүлсний үр өгөөж нь холбогдох өртөг зардаас илүү гарахгүй байх тийм тохиолдол байж болох юм. Жишээлбэл; улсын секторын зарим байгууллагууд нь үйлчилгээний гүйцэтгэлийн тайланг доноруудад гаргаж өгдөг бөгөөд тэдгээр донор нь тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн хамрах хугацаанаас өөр тайлант үеэр бэлтгэхийг шаардаж болно. Тайлант үе тус бүрийн (донорын шаардсан ба санхүүгийн тайлангийн) хувьд үйлчилгээний гүйцэтгэлийн тайланг бэлтгэх нэмэлт өртөг зардал нь түүний үр өгөөжийг зөвтгөн баталдаггүй байж болох юм. Иймээс тухайн тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн зарим мэдээлэл нь өөр тайлант үед хамаарах бөгөөд үүнийг нэмэлт тодруулгаар илэрхийлж болох тийм боломж нөхцлийг энэхүү СБПУ-д хүлээн зөвшөөрөхөөр УСНББОУСЗ шийдвэрлэсэн.

### **Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнах хоёр хандлага**

ДҮ24. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнах өөр өөр хандлагууд, үүн дотроо гарцад илүү чиглэсэн хандлага ба үр дүнд илүү чиглэсэн хандлага байдгийг УСНББОУСЗ нь энэхүү СБПУ-ийг боловсруулах үедээ хүлээн зөвшөөрсөн. Гарцад илүү чиглэсэн хандлага нь үзүүлсэн үйлчилгээний талаархи мэдээллийг тайлагнадаг. Энэ төрлийн мэдээлэл нь нөөцөөр хангагчдад голлон чиглэдэг бөгөөд хэдийгээр үр дүнгийн талаархи мэдээллийг тусган оруулахын тулд анхаарах зүйлсийг өргөжүүлэх боломжтой боловч тухайн ханган нийлүүлсэн нөөцийн хариуд хүлээн авсан үйлчилгээ болон нөөцийг үр ашигтайгаар зарцуулсан эсэх талаар тайлагнахыг юуны өмнө эрмэлздэг. Харин үр дүнд илүү чиглэсэн хандлага нь гүйцэтгэлийн түүхийг өгүүлдэг бөгөөд хэдийгээр тухайн гүйцэтгэлийн түүхийг уг үйлчилгээний өртөгтэй эргэн холбох боломжтой боловч үр дүнгийн биелэлтийн талаар ерөнхийдөө тайлагнадаг. Байгууллага нь өөрийн зорилтуудыг үр дүнгийн нөхцлөөр илэрхийлсэн бол уг тайлагнасан мэдээлэл нь тэрхүү зорилтуудад хүрэхдээ тухайн байгууллага хэр сайн ажилласан эсэхийг тайлбарладаг.

ДҮ25. Хандлага нэг бүрд тусгайлан зориулсан удирдамжийг энэхүү СБПУ-д тусган оруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн боловч зорилтуудын биелэлтийн талаархи уг СБПУ-ийн анхаарах зүйлийг аль хандлагад мөрдөж болно гэсэн үндэслэлээр ийм тусгайлан удирдамж оруулахгүй байхаар шийдвэрлэсэн. Зорилтууддаа нийцүүлэн өөрсдийн тайлагналыг өөрчлөн тохируулахыг байгууллагуудад зөвшөөрөх нь тэдгээр байгууллагууд буюу улс орнууд энэхүү СБПУ-ийг дагаж мөрдөхийн тулд өөрсдийн бие даасан арга хандлагыг гарцад суурилсан хандлагад, эсвэл үр дүнд суурилсан хандлагад нийцүүлэх шаардлагагүй болно гэсэн үг юм. Энэ нь өөр өөр хандлагуудыг мөрдөж буй янз бүрийн байгууллагуудын хувьд энэхүү СБПУ-ийн агуулга хамааралтай болно гэсэн үг юм. Байгууллагуудын үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагнал нь хөгжлийн эхлэлийн шатандаа байх үед тэдгээрийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд нь орцтой ч холбоотой байж болно. Гэвч цаг хугацааны явцад байгууллагуудын хүрэхийг эрмэлзэх туйлын зорилго нь үр ашиг ба үр дүнтэй байдлын аль алиныг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгох мэдээллээс гадна үр дүн болон гарцын талаар дэлгэрэнгүй тайлагнах үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагнал юм. Толилуулсан гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь тухайн байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн товч тодорхой, нэгдмэл үзэл бодлыг хүргэн танилцуулах гэх мэт бүхэл системийг бүрдүүлвэл зохино гэсэн УСНББОУСЗ-ийн доор авч хэлэлцсэн байр суурьтай нийцдэг.

### **Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг толилуулах зарчмууд**

ДҮ26. Энэхүү СБПУ нь үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн толилуулгад мөрдөх зарчмуудыг тогтоодог бөгөөд үүнд мэдээллийн сонголт, байршил, зохион байгуулалтын талаархи шийдвэрт мөрдөх зарчмууд хамаардаг. Энэ СБПУ нь толилуулгын шийдвэрийг гаргахдаа харгалзан үзвэл зохих хүчин зүйлсийг тодорхойлох ба мэдээллийн шаардлагуудын дэлгэрэнгүй

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

жагсаалтыг тусгахын оронд эдгээр зарчмуудын хүрээнд толилуулгын хувьд харгалзан үзэх мэдээллийг ерөнхийдөө санал болгодог. Энэхүү зарчимд суурилсан хандлага нь зөвлөлдөх үе шатны явцад боловсруулсан ба СТ-ийг боловсруулах, уг СТ-д ирүүлсэн хариултуудыг УСНББОУСЗ нягталж шалгах явцад цаашид харгалзан үзсэн уг СБПУ-ийн ерөнхий хандлагын талаархи УСНББОУСЗ-ийн шийдвэртэй нийцдэг. Хэдийгээр энэ СБПУ нь бүх байгууллагуудын толилуулах хэрэгтэй мэдээллийн төрлийг тогтоодог боловч дэлгэрэнгүй цогц мэдээллийг харуулдаггүй. УСНББОУСЗ нь ЗББ-д санал болгосон, уг зарчимд суурилсан хандлагыг хэвээр үлдээсэн бөгөөд зарчимд суурилсан хандлага нь дараах боломж олгодог гэсэн үндэслэлээр түүнийг уг СТ-д тусган оруулсан:

- (а) Байгууллагуудын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудад хамааралтай ба тохиромжтой бөгөөд тухайн мэдээллийн хэрэглэгчдийн хэрэгцээг хангах тэрхүү үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнахад тэдэнд шаардлагатай уян хатан боломжийг байгууллагуудад олгодог;
- (б) Үйлчилгээний гүйцэтгэлийн тайлангаар тухайн хэрэглэгчдийн хэрэгцээг хангах хэмжээг бууруулах, чанарын шинжүүдийг биелүүлэхгүй эсвэл хэт өндөр өртөг зардлаар өгөөж бий болгох “хэт их тодруулга”-ын эрсдлийг бууруулдаг; ба
- (в) Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдэд шаардлагатай үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн толилуулгад хүргэх зарчмуудыг мөрдөхийг байгууллагуудаас шаарддаг.

ДҮ27. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнах гол зарчмууд нь тухайн мэдээллээр хангавал зохих хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн байх явдал гэдгийг УСНББОУСЗ тодорхойлсон бөгөөд тэрхүү хэрэгцээ шаардлагыг зөвлөлдөх үйл явцаар болон янз бүрийн улс орнуудын туршлагыг харгалзан тогтоодог. Эдгээр зарчмууд нь Онолын Үзэл Баримтлалтай нийцсэн байх бөгөөд үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн тайлагналд уг Онолын Үзэл Баримтлалын мөрдөлтийг харгалзан тусгадаг.

### **Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн толилуулга**

*Зөвлөлдөх Баримт Бичгийн хэмжигдэхүүнүүд ба үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн бүрэлдэхүүн хэсгүүд*

ДҮ28. Мэдээллийг үндэслэн толилуулах үйлчилгээний гүйцэтгэлийн дөрвөн хэмжигдэхүүн байдгийг ЗББ-т тайлбарласан. Яагаад, юуг, хэрхэн, хэзээ гэсэн дөрвөн хэмжигдэхүүн нь байгууллагын дараах зүйлстэй холбоотой байдаг:

- (а) Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилгууд;
- (б) Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд;
- (в) Төлөвлөсөн болон бодит гүйцэтгэлийн хоорондох харьцуулалт; ба

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

- (г) Үйлчилгээний нийлүүлэлтэнд цаг хугацааны явцад гарах өөрчлөлт эсвэл олон жилийн зорилгод чиглэсэн явц өрнөлийг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог хугацааны хамрах хүрээ.

ДҮ29. Дараах зүйлсийг байгууллага тайлагнах хэрэгтэй эсэхийг тогтоох үед энэхүү СБПУ-ийн мэдээллийн хамралтын сонголтын хувьд эдгээр дөрвөн хэмжигдэхүүнийг харгалзан үздэг:

- (а) Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын, үүнд дотроо тэдгээр зорилтуудыг биелүүлэх хэрэгцээ буюу эрэлтийн талаархи мэдээлэл (“яагаад” гэсэн хэмжигдэхүүн);
- (б) Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын биелэлтийг харуулах гүйцэтгэлийн үзүүлэлтүүд (“юуг” гэсэн хэмжигдэхүүн);
- (в) Бодит гүйцэтгэлийг төлөвлөсөн (эсвэл зорилтот) үр дүнтэй харьцуулалт, үүн дотроо тэдгээр үр дүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаархи мэдээлэл (“хэрхэн” гэсэн хэмжигдэхүүн); ба
- (г) Тухайн тайлант үеийн болон өмнөх тайлант үеийн бодит гүйцэтгэлийн мэдээллийг толилуулах үйлчилгээний гүйцэтгэлийн жил тутмын мэдээлэл (“хэзээ” гэсэн хэмжигдэхүүн).

ДҮ30. Эдгээр дөрвөн хэмжигдэхүүнтэй холбоотой үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн бүрэлдэхүүн хэсгүүдийг ЗББ-т бас тогтоосон байдаг. Энэхүү СБПУ-ийн мэдээллийн хамралтын сонголт нь уг ЗББ-ийн дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг харгалзан үзсэн:

- (а) Зорилтуудын биелэлтийн талаархи хүүрнэсэн хэлэлцүүлэг;
- (б) Тухайн тайлагнасан үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн “хүчин зүйлс”-ийн талаархи мэдээлэл (энэ СБПУ-д “суурь” гэж нэрлэсэн); ба
- (в) Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд ба тэдгээр үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын биелэлтийн талаархи мэдээлэл.

*Тусгайлсан шаардлага биш, харин зарчмууд*

ДҮ31. Байгууллагуудын үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн толилуулга нь дараах зүйлсээс хамааран янз бүр байдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн:

- (а) Байгууллагын үзүүлдэг үйлчилгээнүүд;
- (б) Байгууллагын шинж төрөл; ба
- (в) Байгууллагын үйл ажиллагаа явуулдаг зохицуулалтын орчин буюу бусад хамрах хүрээ.

ДҮ32. Үзүүлсэн үйлчилгээ, үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд, үйлчилгээний гүйцэтгэлийн холбогдох үзүүлэлтүүд нь эдгээр янз бүрийн хүчин зүйлсээс хамаардаг учраас толилуулах ёстой гүйцэтгэлийн тодорхой үзүүлэлтүүдийг энэ энэ СБПУ-д заах хэрэггүй гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн. Харин

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

тайлагнавал зохих мэдээллийн ерөнхий төрлүүдийг тогтоож, үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг сонгохдоо чанарын шинжүүдийг биелүүлэх талаархи заавар удирдамжаар хангах хэрэгтэй гэж үзсэн.

ДҮ33. Энэ СБПУ нь толилуулж болох төрөл бүрийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон боловч гүйцэтгэлийн тодорхой нэг үзүүлэлт толилуулахыг шаардаагүй. Үр ашгийн болон үр дүнтэй байдлын үзүүлэлтүүд нь гүйцэтгэлийн эдгээр төлөв байдлуудыг шууд харгалзан үздэг боловч үр ашиг ба үр дүнтэй байдлыг үнэлэхэд хэрэглэгчдэд зориулсан мэдээллээр хангах энэ СБПУ-ийн зорилго нь гүйцэтгэлийн тэрхүү хоёр төрлийн үзүүлэлтүүдийг толилуулах ёстой гэсэн үг биш юм. Тухайлбал; гарц ба тэдгээрийн өртгийн талаархи мэдээллийг ашиглан үр ашгийг тооцоолж болно. Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд, түүнчлэн тэдгээр үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудыг хүрсэн үр дүнтэй харьцуулсан мэдээллийг ашигласнаар үр дүнтэй байдлыг үнэлж болно.

*Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн талаархи товч тодорхой, нэгдмэл байр суурийг илэрхийлэх мэдээлэл*

ДҮ34. Зарчимд чиглэсэн хандлага нь үйлчилгээний гүйцэтгэлийн тайлагналын хөгжлийн эхлэлийн үе шатанд энэ СБПУ-ийн заавар удирдамжийг ханган мөрдөх ба өөрсдийн тайлагналын одоогийн чадавхид нийцүүлэн үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тайлагнах боломжийг байгууллагуудад олгодог тул уг хандлага тохиромжтой гэж УСНББОУСЗ үзсэн. Гэвч хэрэглэгчид нь байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийг, үүн дотроо түүний зорилтуудын биелэлт, түүнчлэн гарцыг бий болгох ба үр дүнд хүрэхийн тулд нөөцийг үр ашигтай, үр дүнтэй ашигласан хэмжээг үнэлэх боломж олгохын тулд үйлчилгээний гүйцэтгэлийн сайн чанартай мэдээлэл тайлагнах шаардлагатай гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Үнэн хэрэгтээ, толилуулсан гүйцэтгэлийн цогц үзүүлэлтүүд нь тухайн байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн товч тодорхой, нэгдмэл үзэл бодлыг хүргэн танилцуулах гэх мэт бүхэл системийг бүрдүүлвэл зохино.

*Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн сонголт*

ДҮ35. Энэхүү СБПУ нь өөрсдийн үзүүлсэн үйлчилгээний хувьд орц, гарц, үр дүн, үр ашиг, үр дүнтэй байдал гэсэн гүйцэтгэлийн үзүүлэлтийн бүх таван төрлийг тайлагнахыг байгууллагуудаас шаардах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Энэ нь байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн дэлгэрэнгүй хамралтыг бий болгох үр дүнтэй боловч байгууллагын үйлчилгээний бодит гүйцэтгэлийн гол анхаарах зүйлийг тусгаагүй байж болох юм. Практикт, байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд цаг хугацааны явцад өөрчлөгдөх магадлалтай байдаг. Тухайлбал; үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд нь эхлээд орцод, дараа нь, гарц ба үр ашигт, түүний дараа үр дүнд чиглэж болох юм. Хэрэв байгууллага нь өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудтай нийцүүлэхийн тулд гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн тайлагналыг тохируулах чадвар боломжтой бол уг толилуулсан мэдээлэл нь тухайн санхүүгийн



## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

тайлагналын зорилтуудын биелэлтэнд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээгээр хэрэглэгчдэд ач холбогдолтой байх ба чанарын шинжүүдийг хангах илүү их магадлалтай байдаг. Иймээс бүх таван төрлийн үзүүлэлтийг тайлагнахыг энэ СБПУ-аар шаардахгүй, харин өөрийн тайлагнах гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн төрлийг байгууллага хэрхэн сонгох талаархи удирдамжаар хангах хэрэгтэй гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн.

ДҮ36. Үр дүнгийн үзүүлэлтүүд тайлагнахыг энэ СБПУ-аар байгууллагуудаас шаардах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь мөн авч үзсэн. Үр дүнгийн мэдээлэл нь үйлчилгээ үзүүлэх эцсийн шалтгаан буюу нийгэмд тухайн үйлчилгээгээр нөлөөлөх үр дагаварт чиглэдэг учраас хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг. Гэвч үр дүнгийн мэдээллийг бэлтгэхэд байгууллагуудад ихээхэн төвөгтэй байдаг. Ялангуяа, байгууллага нь өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн тайлагналын хөгжлийн эхлэлийн үе шатанд байгаа, эсвэл тухайн тайлагнагч байгууллага нь нэг ижил үр дүнд хувь нэмрээ оруулдаг олон байгууллагуудын нэг байх тохиолдолд маш хэцүү байж болно. Иймээс үр дүнгийн талаархи мэдээллийг байгууллагууд толилуулахыг энэхүү СБПУ-аар дэмжих боловч заавал шаардахгүй байхаар УСНББОУСЗ шийдвэрлэсэн.

### *Үйлчилгээний нийт өртөг*

ДҮ37. Үйлчилгээний нийт өртөгт ямар өртөг зардлыг оруулах талаар удирдамж гаргах эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Үйлчилгээний өртөг тооцолт нь удирдлагын нягтлан бодох бүртгэлийн асуудлуудыг хамардаг. Үйлчилгээний нийт өртгийн утга агуулга нь улс орон ба/буюу байгууллагын тусгайлсан шинжтэй байж болно. Байгууллагууд нь өөрсдийн санхүүгийн тайланд толилуулдаг нийт зардалтай адилтгах үйлчилгээний нийт өртгийг тайлагнаж болох юм. Нөгөө талаас, байгууллагууд нь зарим өртгийг, тухайлбал нэмэгдэл зардал эсвэл зээлийн өртөг гэх мэт зарим төрлийн зардлыг оруулахгүй байж болно. Үүний үр дүнд үйлчилгээний нийт өртөг нь тухайн санхүүгийн тайланд толилуулсан нийт зардлаас өөр байдаг. Иймээс УСНББОУСЗ нь үйлчилгээний нийт өртөг гэдгээр юуг илэрхийлэх эсэхийг тусгайлан заахгүй байхаар шийдвэрлэсэн.

### *Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн байршил*

ДҮ38. Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тухайн санхүүгийн тайланг агуулсан НЗСТ-д, эсвэл тусдаа НЗСТ-д тусгах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Олон улс үндэстэн нь үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг шинж төрлийн хувьд өөр, иймээс тухайн санхүүгийн тайлангаар хангаж буй мэдээллээс тусдаа байх хэрэгтэй гэж үздэг боловч үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг санхүүгийн тайланг агуулсан уг тайлан илтгэлд нэгтгэн оруулах хэрэгтэй, хоёр тусдаа мэдээлэл нь ач холбогдолгүй гэж үздэг улс орнууд бас байдаг гэдгийг цохон тэмдэглэсэн. Энэхүү хоёр хандлагын аль аль нь ач холбогдолтой юм. Улс орнуудын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөхийн тулд УСНББОУСЗ нь үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг тухайн санхүүгийн тайланг агуулсан тайлан илтгэлд эсвэл тусдаа тайлан илтгэлд тусган тайлагнахын

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

аль алиныг энэхүү СБПУ-аар байгууллагуудад зөвшөөрөх хэрэгтэй гэж шийдвэрлэсэн.

### *Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийн зохион байгуулалт*

ДҮ39. Энэхүү СБПУ-аар дараах зүйлсийг гүйцэтгэх хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн:

- (а) Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг зохион байгуулах нэг арга замыг санал болгох, үүнд харгалзан үзэх үндсэн арга нь “үйлчилгээний гүйцэтгэлийн тайлан” гэж нэрлэгдэх хүснэгтэн хэлбэр байдаг; эсвэл
- (б) Мэдээллийн зохион байгуулалтын боломжит өөр өөр хандлагуудаас сонголт хийх үед улс орнууд ба/буюу тайлан бэлтгэгчдийг удирдан чиглүүлэхийн тулд баримталвал зохих зарчмуудыг тогтоох.

ДҮ40. Зарим улс орны хувьд, үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээллийг “үйлчилгээний гүйцэтгэлийн тайлан”-д тайлагнах талаархи шаардлагууд байдаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Өөр зарим улс орны хувьд, тайлан бэлтгэгч нар нь тодорхой төрлийн үйлчилгээ, хүссэн үр дүн, мэдээллийг тайлагнах шаардлагатай төлөвлөсөн биелэлтийг харгалзан лавлагаа болгосноор мэдээллийг хамгийн сайнаар хэрхэн зохион байгуулахыг тодорхойлох зарчмуудыг дагаж мөрддөг. Олон төрлийн үйлчилгээний хувьд тоон буюу “хураангуй тайлбар тодорхойлолт” (жишээлбэл; “хангалттай эсвэл хангалтгүй”) хэлбэрийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тайлагнадаг тохиолдолд мэдээллийг хүснэгт эсвэл тайлан хэлбэрээр зохион байгуулах нь ойлгомжтой ба зэрэгцүүлэгдэх байдлыг сайжруулдаг. Гэвч тайлангийн загвар нь зөвхөн зөвшөөрөгдсөн толилуулгын хэлбэртэй байвал үйлчилгээний биелэлтийг буруу илэрхийлж, эсвэл дутуу тайлбарлан тодорхойлж болох юм.

ДҮ41. Энэ СБПУ нь уг шийдвэрт хамаарах зарчмуудад голлон чиглэх хэрэгтэй гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн. Тайлагналын стандарт бүтцийг тусгайлан заахын оронд зарчмуудад анхаарал хандуулснаар энэхүү СБПУ нь дараах зүйлсэд нийцэн тохирсон мэдээллийн зохион байгуулалтын сонголт хийх боломж олгодог:

- (а) Гүйцэтгэлийн мэдээллийг толилуулж буй үйлчилгээний шинж төрөл;
- (б) Санхүүгийн тайлагналын зорилтууд болон чанарын шинжүүдийн биелэлтэнд дэмжлэг үзүүлэхийн тулд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага; ба
- (в) Зохицуулалтын хүрээ, үүн дотроо тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг зохицуулалтын орчин.

ДҮ42. Хэдийгээр энэ нь стандартчилсан байдлыг багасгах ба байгууллагуудын хоорондох зэрэгцүүлэгдэх боломжит байдлыг сулруулах үр дүнтэй байж болох боловч үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь уг тайлагнасан үйлчилгээний олон янз байдлаас хамааран тухайн санхүүгийн тайлангийн мэдээллээс өөр байдаг. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь өөр хоорондоо

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

зэрэгцүүлэгдэх боломжтой байхаас бусад тохиолдолд толилуулгын нэг загвар ашиглах нь байгууллага хоорондын зэрэгцүүлэгдэх боломжтой байдалд ач тус үзүүлэхгүй, харин тухайн байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд, түүнчлэн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд үзүүлдэг үйлчилгээнд тусгайлан нийцсэн байдлаар мэдээллийг зохион байгуулах боломж олгосноор хүртэх байсан өгөөжийг алдагдуулдаг.

### **2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд СБПУ 3-д хийсэн хянан засварлалт**

ДҮ43. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь бүх УСНББОУС дахь хэллэгт дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (a) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Үлгэрчилсэн жишээ

*Энэхүү Үлгэрчилсэн жишээ нь СБПУ 3-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

- ҮЖ1. Энэ Хавсралт дахь жишээнүүд нь таамагласан нөхцөл байдлуудыг илэрхийлнэ. Хэдийгээр эдгээр жишээний зарим төлөв байдал нь бодит нөхцөл байдалд илрэн гарч болох боловч СБПУ 3-ыг мөрдөх үедээ тухайн тодорхой байдлын холбогдох бүх баримт материал болон нөхцөл байдлуудыг үнэлэх шаардлагатай байдаг. Өртгийг тодорхойлох тохиолдолд дүнг “валютын нэгж” (ВН)-ээр илэрхийлсэн.
- ҮЖ2. Энэ Хавсралтын эхний хэсэг нь тус СБПУ-д тодорхойлсон, нэр томъёонуудын жишээг жагсаан харуулсан. Тодорхойлсон бүх нэр томъёонд зориулсан жишээнүүдийн бүгдийг хамарсан жагсаалтыг энд харуулахыг эрмэлзээгүй болно. Эдгээр жишээ нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг лавлагаа болгосноор янз бүрийн нэр томъёоны утгыг ихэвчлэн үлгэрчлэн харуулсан. Жишээнүүд нь улаан бурхан өвчнөөс сэргийлэхийн тулд нялх хүүхдүүдийг вакцинжуулах нэг төрлийн үйлчилгээнд голлон чиглэнэ. Байгууллага нь өөрийн гарц (улаан бурханы вакцин)-ыг үйлдвэрлэхийн тулд янз бүрийн орцыг ашигладаг. Тэдгээр гарц нь хүссэн үр дүнд (шууд эсвэл шууд бусаар) хүргэнэ гэж найдаж байна.
- ҮЖ3. Энэ Хавсралтын хоёр дахь хэсэг нь байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн хүүрнэсэн шинжилгээ ба хэлэлцүүлэгт тусган оруулж болох мэдээллийн үлгэрчилсэн жагсаалтаар хангадаг.

### Нэгдүгээр хэсэг: Тодорхойлсон нэр томъёоны жишээ

- **Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд (ҮГЗ):**

Орц, гарц, үр дүн, үр ашиг гэсэн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг, эсвэл энэхүү дөрвөн үзүүлэлтийн нэг буюу хэд хэдэн үзүүлэлтийг хослуулан ашигласнаар үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудыг илэрхийлж болно гэж СБПУ 3-д заасан. Илэрхийллийн өөр өөр хэлбэрүүд бүхий үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын жишээг доор харуулсан. Эхний жишээнд орцод чиглэсэн, хоёр дахь жишээнд гарцад чиглэсэн, гурав дахь жишээнд үр дүнд чиглэсэн, хамгийн сүүлийн жишээнд үр ашигт чиглэсэн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтыг илэрхийлсэн.

- Вакцинжуулах үйлчилгээнд эмнэлгийн ажилтнуудын 1,200 бүтэн ажлын өдөртэй тэнцэх хугацааг зарцуулна.
- Нялх хүүхдүүдэд нийт 20,000 вакцин хийнэ.
- Улаан бурхан өвчнөөр жил бүр өвчилдөг нялх хүүхдүүдийн хувийн жинг таван жилийн дотор, өөрөөр хэлбэл 20XX оны эцэс гэхэд 65 хувиас 2 хувь болтол бууруулна.
- Вакцин нэг бүрийн нийт өртгийг 5 ВН-ээс 4 ВН болгон бууруулна.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

- **Орц:** Улаан бурханы вакцин хийх үйлчилгээг үзүүлэх ажилтнуудын бүтэн цагаар тооцсон ажлын өдрийн тоо.
- **Гарц:** Улаан бурханы вакцин хийлгэсэн нялх хүүхдүүдийн тоо.
- **Үр дүн:** Улаан бурханаар өвчилсөн нялх хүүхдүүдийн тооны бууралт. (Бууралтыг үнэмлэхүй дүнгээр (улаан бурханаар өвчлөх тохиолдол 5,000-аас бага байх) эсвэл хувийн жингийн бууралтаар (улаан бурханаар өвчлөлт 35 хувиар буурах) илэрхийлж болно).

Үр дүн нь нийгэмд бүхэлд нь, уг нийгмийн хүрээн дэх тодорхой бүлгүүд буюу байгууллагуудад нөлөөлөх үр дагавартай байж болно гэж СБПУ 3-д дурдсан. Гарц нь тухайн байгууллагын үйлчилгээг хүлээн авагчдад харьцангуй шууд нөлөө үзүүлж болох юм. Энэ нь тухайн байгууллагын үйлчилгээг хүлээн авагчид биш боловч тэдгээр үйлчилгээнээс шууд бусаар өгөөж хүртдэг бусад талуудад бас нөлөөлж болно. Мөн тухайн байгууллагын хяналтаас ангид хүчин зүйлс нь түүний үр дүнгийн биелэлтэнд саад учруулах эсвэл дэмжлэг үзүүлэх байдлаар нөлөөлж болно гэдгийг СБПУ 3-д заасан. Доорх эхний жишээ нь уг нийгмийн хүрээн дэх тодорхой бүлэгт нөлөөлөх үр дүнг үлгэрчлэн харуулсан. Хоёр дахь ба гурав дахь жишээнүүд нь үйлчилгээ хүлээн авагчдад үзүүлэх шууд нөлөө болон үйлчилгээ хүлээн авагч бус бусад талуудад үзүүлэх шууд бус нөлөөг үлгэрчлэн харуулсан. Байгууллагын хяналтаас ангид хүчин зүйлс нь уг байгууллагын үр дүнгийн биелэлтэнд дэмжлэг үзүүлэх байдлаар нөлөөлөх нөхцөл байдлыг дөрөв дэх жишээнд харуулсан.

- Нийгэм-эдийн засгийн арван ангиллаас хамгийн доод давхаргын нялх хүүхдүүдийн улаан бурханы өвчлөлийн тохиолдлыг 35 хувиар бууруулах.
- Тухайн байгууллагын үзүүлсэн улаан бурханы вакцинжуулалтын үйлчилгээг хүлээн авагчдын улаан бурханы өвчлөлийн тохиолдлын тооны бууралт нь уг байгууллагын үйлчилгээг хүлээн авагчдад үзүүлэх шууд үр нөлөөний жишээ юм.
- Вакцинд хамрагдсан хүүхдүүдийн сурдаг тухайн сургуульд суралцдаг боловч вакцин хийлгээгүй хүүхдүүд нь улаан бурхан өвчний халдвар авах эрсдэл буурах учраас уг байгууллагын вакцинжуулах үйлчилгээ нь тэдэнд мөн шууд бусаар нөлөө үзүүлнэ.
- Зэргэлдээх бүс нутаг дахь улаан бурхан өвчний дэгдэлт нь уг өвчинтэй холбоотой эрүүл мэндийн эрсдлийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр ихээхэн мэдээ нэвтрүүлэг хийхэд хүргэсэн бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг өөр байгууллагын зүгээс тэрхүү зэргэлдээх бүс нутагт вакцинжуулалтыг ихээхэн нэмэгдүүлсэн. Эдгээр хүчин зүйлс нь өөрийн бүс нутагт улаан бурхан өвчний тохиолдлыг бууруулах уг байгууллагын үр дүнгийн биелэлтэнд дэмжлэг үзүүлсэн. Өөр бүс нутаг дахь хүчин зүйлс (улаан бурхан өвчин дэгдэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ,

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

нэвтрүүлэг явуулах, вакцинжуулалтыг нэмэгдүүлэх) нь уг байгууллагын хяналтаас ангид байдаг.

- **Үр ашиг:**

Үр ашиг нь (а) орц ба гарцын, эсвэл (б) орц ба үр дүнгийн хоорондох харилцан хамаарал юм гэж СБПУ 3-д заасан. Доорх “зуйван” хэлбэрийн эхний догол мөр дэх хоёр жишээ нь орц ба гарцын хоорондох харилцан хамаарал байдлаар илэрхийлсэн үр ашгийг үлгэрчлэн харуулна. “Зуйван” хэлбэрийн хоёр дахь догол мөр дэх жишээ нь орц ба үр дүнгийн хоорондох харилцан хамаарал байдлаар илэрхийлсэн үр ашгийг үлгэрчлэн харуулна.

- “Нэг хүүхдийг вакцинжуулах өртөг” нь гарц (вакцин)-ыг орцтой (өртөгтэй) холбох үр ашгийн үзүүлэлтийн жишээ юм. Үр ашгийг жишээлбэл, ажилтны тоо эсвэл ажилтны зарцуулсан хугацаа гэх мэт бусад орцоор бас илэрхийлж болно. Жишээлбэл; эмнэлгийн мэргэшсэн нэг ажилтан нь жил бүр 1,000 вакцин хийх.
- “Улаан бурхан өвчнөөр өвчлөх нялх хүүхдүүдийн тооны бууралт бүрд хамаарах өртөг” нь үр дүнг (улаан бурхан өвчнөөр өвчлөх нялх хүүхдүүдийн тооны бууралт) орцтой (өртөгтэй) холбох үр ашгийн үзүүлэлтийн жишээ юм.

- **Үр дүнтэй байдал:**

Үр дүнтэй байдал нь гүйцэтгэлийн үр дүн ба үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын хоорондох харилцан хамаарал гэж СБПУ 3-д заасан. Иймээс үр дүнтэй байдлын үнэлгээ нь тухайн байгууллагын толилуулж буй үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудаас хамаардаг. Үйлчилгээний гүйцэтгэлийн янз бүрийн зорилтуудын хувьд үр дүнтэй байдлыг доорх гурван жишээнд үлгэрчлэн харуулсан. Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтыг орцоор илэрхийлсэн үеийн үр дүнтэй байдлыг эхний жишээнд, гарцаар илэрхийлсэн тохиолдлыг хоёр дахь жишээнд, үр дүнгээр илэрхийлсэн тохиолдлыг гурав дахь жишээнд үлгэрчлэн харуулсан.

- Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилт нь 20XX оны 3-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн туршид улаан бурханы вакцин хийх үйлчилгээнд эмнэлгийн ажилтнуудын 20,000 ажлын цаг зарцуулах явдал байсан. Хүрсэн гүйцэтгэлийн үр дүн нь эмнэлгийн ажилтнуудын 18,000 ажлын цаг байсан. Иймээс энэ талбар дахь уг байгууллагын үр дүнтэй байдал нь 90% юм.
- Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилт нь 20XX оны 3-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн туршид улаан бурханы 100,000 вакциныг нялх хүүхдүүдэд хийх явдал байсан. Хүрсэн гүйцэтгэлийн үр дүн нь 99,000 вакцин байсан. Иймээс энэ талбар дахь уг байгууллагын үр дүнтэй байдал нь 99% юм.
- Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилт нь улаан бурхан өвчнөөр өвчлөх нялх хүүхдүүдийн тоог өмнөх жилтэй харьцуулахад 3,000-аар бууруулах явдал байсан. Хүрсэн гүйцэтгэлийн үр дүн нь улаан бурхан

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

өвчнөөр өвчилсөн нялх хүүхдүүдийн тооны бууралт 3,000 байсан. Иймээс энэ талбар дахь уг байгууллагын үр дүнтэй байдал нь 100% юм.

### • Гүйцэтгэлийн үзүүлэлт - Чанарын шинжтэй тайлбар тодорхойлолт:

Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь тоон хэмжүүр, чанарын хэмжүүр ба/буюу байгууллага нөөцийг ашиглах, үйлчилгээг үзүүлэх болон өөрийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудыг биелүүлэх хэмжээ ба шинж төрлийн талаархи чанарын шинжтэй тайлбар тодорхойлолт юм гэж СБПУ 3-д заасан. Чанарын тайлбар тодорхойлолт байдлаар илэрхийлсэн гүйцэтгэлийн үзүүлэлтийг доорх жишээнд үлгэрчлэн харуулсан:

*Бусад улс үндэстнүүдтэй Засгийн газрын харилцах харилцаанд, үүн дотроо худалдааны харилцаанд дэмжлэг үзүүлэх тус Засгийн газрын нэгж (Яам) нь өөрийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн нэг болгон дараах чанарын шинжтэй тайлбар тодорхойлолтыг ашигладаг:*

Латин Америктай энэ жил хийх харилцааны хүрээнд, Сайд нараар ахлуулсан, үндэсний засгийн газрын түвшний бизнесийн хэд хэдэн амжилттай арга хэмжээг, түүнчлэн сайд нарын уулзалтыг бүсийн хоёр чуулга уулзалтаар зохион байгуулахаар төлөвлөж байна. Яам нь тус бүс нутгийн хэд хэдэн улс орноос хийгдэх сайд нарын түвшний айлчлалын хувьд хүлээн авалтын болон бусад дэмжлэг үзүүлэх бөгөөд хоёр талын гадаад бодлого зөвлөгөөнийг зохион байгуулна. Зөвлөгөөнөөр чөлөөт худалдааны хэлцлийн тааламжтай нөхцлүүдийг авч хэлэлцэнэ. Консулын газар болон өргөмжит консулыг нэмэгдүүлснээр Латин Америкийн хэд хэдэн улс орон дахь дипломат харилцааны сүлжээг өргөжүүлнэ.

### Хоёрдугаар хэсэг: Хүүрнэсэн хэлэлцүүлэг ба шинжилгээ-Мэдээллийн төрлүүд

Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийг үнэлэхэд хэрэглэгчдэд туслалцаа үзүүлэхийн тулд хүүрнэсэн хэлэлцүүлэг ба шинжилгээнд тусгаж болох мэдээллийн янз бүрийн төрлүүдийн жишээг дараах жагсаалтанд харуулсан:

- (а) Тухайн үйлчилгээний гүйцэтгэлийн биелэлт, сул тал, асуудал.
- (б) Үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудын биелэлтэнд (эсвэл үл биелэлтэнд) нөлөөлж болох хүчин зүйлсийн тодорхойлолт ба хэлэлцүүлэг.
- (в) Үр дүнтэй байдлын үзүүлэлтүүд.
- (г) Төлөвлөсөн ба бодит гүйцэтгэлийн хоорондох зөрүүгийн хэлэлцүүлэг.
- (д) Доорх байдлаар хийгдэх үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт:
  - (i) Хугацаагаар;

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

- (ii) Чухал үе шатаар; ба/буюу
- (iii) Бодит болон төлөвлөсөн гүйцэтгэлийн үр дүнгээр.
- (е) Хэрэв үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтууд буюу толилуулсан гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь өмнөх жил толилуулсан зорилтууд буюу үзүүлэлтүүдтэй харьцуулахад өөрчлөгдсөн бол өөрчлөлт (өөрчлөлтүүд)-ийн шалтгаан.
- (ж) Байгууллага нь олон жилийн үйлчилгээний гүйцэтгэлийн зорилтуудтай тохиолдолд тэдгээрийн биелэлтэнд чиглэсэн явц өрнөлийн талаархи хүүрнэсэн тайлбар.
- (и) Үр дүнг тайлагнадаг тохиолдолд тэдгээр үр дүнг тухайн байгууллагын үйл ажиллагаануудад хамааруулж болох хэмжээний талаархи мэдээлэл.
- (к) Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн хувьд тухайн тайлант үеийн туршид олж хуримтлуулсан чухал туршлага мэдлэг, үүн дотроо хамааралтай тохиолдолд уг үйлчилгээний гүйцэтгэлд нөлөөлөх асуудлуудыг авч үзэх арга зам болон цаашдын үнэлгээ шаардах талбаруудын талаархи төлөвлөгөө.
- (л) Үйлчилгээний нийлүүлэлттэй холбоотой эрсдлүүдийн тодорхойлолт ба хэлэлцүүлэг, хэрэв үйлчилгээний хувьд эрсдлийн үнэлгээ хийсэн бол ийм эрсдлийг тэнцвэржүүлэх шийдвэрийг хэрхэн мэдээлж, удирдан зохицуулах талаархи мэдээлэл.
- (м) Үзүүлсэн үйлчилгээний санаатай эсвэл санамсаргүй, шууд буюу шууд бус үр дагаврын тодорхойлолт ба хэлэлцүүлэг.

Хэрэв байгууллага нь төлөвлөсөн ба бодит биелэлтийн хоорондох зөрүүгийн талаар тайлбар хэлэлцүүлэг бол уг хэлэлцүүлэг нь тухайлбал, дараах зүйлсийг агуулсан байж болно:

- (а) Хэлбэлзэлийн хэмжээний тодорхойлолт; ба
- (б) Хэлбэлзэлд нөлөөлсөн хүчин зүйлс. (Жишээлбэл; гадаад хүчин зүйлс, дотоод үйл явцын үр ашигтай эсвэл үр ашиггүй байдал, нөөцийн бэлэн боломжтой байдал, үйлчилгээ үзүүлэх талаархи засгийн газрын шийдвэр.)

Үр дүнгийн биелэлтэнд тухайн байгууллагын хяналтаас ангид хүчин зүйлс ямагт нөлөө үзүүлж байдаг. Хэрэв байгууллага нь үр дүнгийн талаархи хүүрнэсэн хэлэлцүүлэг ба шинжилгээг хийдэг бол тэрхүү үр дүнг сайжруулах эсвэл муутгахад тухайн байгууллагын үзүүлсэн үүргийг хэрэглэгч нар хэтрүүлэн үнэлэхэд хүргэхээргүй байдлаар уг тодруулга нь хангалттай байвал зохино. Үр дүнгийн мэдээллийг тайлагнадаг тохиолдолд дараах мэдээлэл нь хэрэглэгчдэд ач холбогдолтой байж болно:

- (а) Үр дүнг тухайн байгууллагын үйл ажиллагаануудад хамааруулж болох хэмжээ, ба
- (б) Үр дүнд нөлөөлж болох бусад хүчин зүйлс.



## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТАЙЛАГНАЛ

Төрийн үйлчилгээ үзүүлэлт нь төрөл бүрийн эрсдлийн тэвчиж болох хэмжээний талаархи тодорхой параметрууд бүхий эрсдлийн үнэлгээг, үүн дотроо оролцооны шийдвэрийн хувьд буруу эерэг ба буруу сөрөг байх эрсдлийн үнэлгээг ямагт агуулсан байдаг. Өөрийн үйлчилгээний нийлүүлэлтийн нэг хэсэг байдлаар эрсдлийг тухайн байгууллага хэрхэн үнэлдэг талаархи мэдээлэл нь уг байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлтэй холбоотой хэрэглэгчдийн ойлголтод дэмжлэг үзүүлдэг.

# ТОДОРХОЙЛСОН НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

Энэ Тайлбар толь нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл батлан гаргасан аккруэл суурьт, 40 ширхэг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт (УСНББОУС)-д тодорхойлсон бүх нэр томъёог агуулсан болно. Эдгээр УСНББОУС-уудын жагсаалтыг энэ Тайлбар толийн арын хавтасны өмнө харуулсан. Энэ Тайлбар толь нь Мөнгөн Суурьт УСНББОУС, *Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал*-д тодорхойлсон нэр томъёонуудыг агуулаагүй болно. Хэрэглэгчид нь тэдгээр нэр томъёог уг Мөнгөн Суурьт УСНББОУС-аас үзэж танилцах хэрэгтэй.

## Тодорхойлолт

Аккруэл суурьт УСНББОУС-ын харилцан лавлагааг Стандартын дугаар болон параграфын дугаараар хийсэн. Жишээлбэл; 1.7 нь УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-ын 7-р параграф гэсэн утгатай болохыг хэрэглэгчдэд зааж өгнө. Хаалтан доторх лавлагаа нь үг хэллэгийн хувьд бага зэрэг өөр гэдгийг илэрхийлнэ.

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>нягтлан бодох бүртгэлийн суурь</b>	Аккруэл суурьт УСНББОУС болон мөнгөн суурьт УСНББОУС-д тодорхойлсон нягтлан бодох бүртгэлийн аккруэл буюу мөнгөн суурь.	24.7
<b>нягтлан бодох бүртгэлийн бодлого</b>	Санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик.	3.7
<b>аккруэл суурь</b>	Ажил гүйлгээ ба үйл явдлыг тэдгээрийн гарч тохиолдсон үед (зөвхөн мөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийг хүлээн авсан буюу төлсөн үед биш) хүлээн зөвшөөрөх нягтлан бодох бүртгэлийн суурь юм. Иймээс ажил гүйлгээ ба үйл явдлыг тэдгээрийн хамаарах тайлант үед нягтлан бодох бүртгэлд бүртгэж, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Аккруэл нягтлан бодох бүртгэлийн дагуу хүлээн зөвшөөрдөг элементүүд нь хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал юм.	1.7
<b>худалдан авсан үйл ажиллагаа</b>	Худалдан авалтын үр дүнд хяналтыг нь нэгтгэгч олж авсан үйл ажиллагаа	40.5

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
нэгтгэгч	Худалдан авалтын үр дүнд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авсан байгууллага.	40.5
худалдан авалт	Нэгдэлд оролцогч нэг тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг бөгөөд уг нэгдэл нь нийлүүлэлт биш гэсэн нотолгоотой байх улсын секторын нэгдэл.	40.5
худалдан авалтын өдөр	Уг худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг нэгтгэгч олж авсан өдөр.	40.5
идэвхитэй зах зээл	<p>Дараах бүх нөхцөл хангагдсан зах зээл юм:</p> <p>(а) Тухайн зах зээлд арилждаг зүйлс нь ижил төсөөтэй;</p> <p>(б) Арилжаанд оролцоход бэлэн, худалдан авагч ба борлуулагчийг хүссэн үедээ ихэвчлэн олж чадах;</p> <p>(в) Үнэ нь олон нийтэд нээлттэй, бэлэн байх.</p>	21.14
актуар олз, гарз	<p>Дараах зүйлсээс бүрдэнэ:</p> <p>(а) Туршлагад үндэслэсэн тохируулга (өмнөх актуар төсөөлөл ба бодитойгоор гарч тохиолдсон зүйлийн хоорондох зөрүүгийн үр нөлөө); ба</p> <p>(б) Актуар төсөөллийн өөрчлөлтийн үр нөлөө.</p>	25.10
<p>2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.</p>	<p>(а) Туршлагад үндэслэсэн тохируулга (өмнөх актуар төсөөлөл ба бодитойгоор гарч тохиолдсон зүйлийн хоорондох зөрүүгийн үр нөлөө); ба</p> <p>(б) Актуар төсөөллийн өөрчлөлтийн үр нөлөө.</p>	
актуар олз, гарз	<p>Дараах зүйлсийн улмаас тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэд гарсан өөрчлөлт юм:</p> <p>(а) Туршлагад үндэслэсэн тохируулга (өмнөх актуар төсөөлөл ба бодитойгоор гарч тохиолдсон зүйлийн хоорондох зөрүүгийн үр нөлөө); ба</p> <p>(б) Актуар төсөөллийн өөрчлөлтийн үр нөлөө.</p>	39.8
<p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>	<p>(а) Туршлагад үндэслэсэн тохируулга (өмнөх актуар төсөөлөл ба бодитойгоор гарч тохиолдсон зүйлийн хоорондох зөрүүгийн үр нөлөө); ба</p> <p>(б) Актуар төсөөллийн өөрчлөлтийн үр нөлөө.</p>	

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>хөдөө аж ахуйн үйл ажиллагаа</b>	<p>Байгууллага дараах зорилгоор биологийн хувьсал болон биологийн хөрөнгөөс үр шим хүртэлтийг удирдан явуулах үйл ажиллагаа юм:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Борлуулах;</li> <li>• Үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах; эсвэл</li> <li>• Борлуулах эсвэл үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилахын тулд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн буюу нэмэлт биологийн хөрөнгө болгон хувиргах.</li> </ul>	27.9
<b>хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн</b>	Тухайн байгууллагын биологийн хөрөнгөөс хүлээн авсан бүтээгдэхүүн.	27.9
<b>нийлүүлэлт</b>	<p>Үр дүнгийн байгууллага үүсэн бий болгоход хүргэдэг бөгөөд дараах хоёрын аль нэг байна:</p> <p>(а) Тухайн нэгдэлд оролцогч аль нэг тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаггүй улсын секторын нэгдэл; эсвэл</p> <p>(б) Тухайн нэгдэлд оролцогч нэг тал нь нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны хяналтыг олж авдаг бөгөөд нийлүүлэлтийн эдийн засгийн мөн чанарыг тэрхүү нэгдэл агуулсан гэсэн нотолгоотой байх улсын секторын нэгдэл.</p>	40.5
<b>нийлүүлэх өдөр</b>	Нэгдэгч үйл ажиллагаануудын хяналтыг тухайн үр дүнгийн байгууллага олж авсан өдөр.	40.5
<b>хорогдуулга</b>	Биет бус хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт.	31.16

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг</b>	Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн буцаан төлөлтийг хасаж, уг анхны дүн ба дуусгавар болгох дүнгийн хоорондох аливаа зөрүүгээс үр ашигт хүүний аргыг ашиглан тооцсон, хуримтлагдсан хорогдуулгыг нэмэх буюу хасаж, үнэ цэнийн бууралт буюу үл цуглуулагдах байдлын аливаа хасагдуулгыг (шууд эсвэл хасагдуулгын данс ашигласнаар) хассан дүн юм.	29.10
<b>жилийн төсөв</b>	Нэг жилийн хувьд батлагдсан төсөв юм. Тухайн төсвийн жилээс хойшхи тайлант үеүдийн хувьд хэвлэн нийтэлсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл нь үүнд хамаарахгүй.	24.7
<b>төсвийн хуваарилалт</b>	Хууль тогтоох буюу адилтгах эрх бүхий этгээдийн тусгайлан тодорхойлсон зорилгод зориулан мөнгө санг хуваарилахын тулд хууль тогтоогч байгууллагаас олгосон зөвшөөрөл.	24.7
<b>батлагдсан төсөв</b>	Хууль, төсвийн хуваарилалтын мэдэгдэл, засгийн газрын тогтоол болон тухайн төсвийн хугацааны урьдчилан төсөөлсөн орлого буюу мөнгөн орлоготой холбоотой бусад шийдвэрээр үүсэх зарлагын эрх.	24.7
<b>хөрөнгө</b>	Өнгөрсөн үйл явдлын үр дүнд байгууллага хяналтандаа оруулсан бөгөөд түүнээс уг байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болохоор хүлээгдэж буй нөөц.	1.7
<b>хөрөнгийн дээд хязгаар</b>	Тухайн хөтөлбөрөөс буцаан олгох эсвэл уг хөтөлбөрт төлөх ирээдүйн шимтгэлийг бууруулах хэлбэрээр бий болох аливаа эдийн засгийн үр өгөөжийн өнөөгийн үнэ цэнэ.	39.8

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<p><b>ажилтны урт хугацааны тэтгэмжийн сангийн эзэмшиж буй хөрөнгө</b></p> <p>2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.</p>	<p>Дараах хөрөнгүүдийг (тайлагнагч байгууллагын гаргасан үл шилжүүлэгдэх санхүүгийн хэрэглүүрээс бусад) хэлнэ:</p> <p>(а) Тухайн тайлагнагч байгууллагаас хууль эрх зүйн хувьд тусгаар бөгөөд зөвхөн ажилтны тэтгэмжийг төлөх буюу санхүүжүүлэхийн тулд оршин буй тийм байгууллагын (сангийн) эзэмшиж байгаа;</p> <p>(б) Зөвхөн ажилтны тэтгэмжийг төлөх буюу санхүүжүүлэхэд ашиглагдах боломжтой ба тухайн тайлагнагч байгууллагын (дампуурлын үед ч гэсэн) зээлдүүлэгчдэд төлбөр хийхэд ашиглагдах боломжгүй бөгөөд доор дурдсан аль нэг тохиолдлоос бусад үед тайлагнагч байгууллагад буцаан олгогдохгүй:</p> <p>(i) Сангийн үлдэгдэл хөрөнгө нь тухайн хөтөлбөрийн эсвэл тайлагнагч байгууллагын ажилтны холбогдох бүх тэтгэмжийн үүргийг барагдуулахад хангалттай байх; эсвэл</p> <p>(ii) Ажилтны тэтгэмжийг аль хэдийн төлсөн тайлагнагч байгууллагад тэрхүү төлбөрийг нөхөн олгохын тулд хөрөнгийг уг байгууллагад буцаах.</p>	<p>25.10</p>

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<p><b>ажилтны урт хугацааны тэтгэмжийн сангийн эзэмшиж буй хөрөнгө</b></p> <p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>	<p>Дараах хөрөнгүүдийг (тайлагнагч байгууллагын гаргасан үл шилжүүлэгдэх санхүүгийн хэрэглүүрээс бусад) хэлнэ:</p> <p>(а) Тухайн тайлагнагч байгууллагаас хууль эрх зүйн хувьд тусгаар бөгөөд зөвхөн ажилтны тэтгэмжийг төлөх буюу санхүүжүүлэхийн тулд оршин буй тийм байгууллагын (сангийн) эзэмшиж байгаа;</p> <p>(б) Зөвхөн ажилтны тэтгэмжийг төлөх буюу санхүүжүүлэхэд ашиглагдах боломжтой ба тухайн тайлагнагч байгууллагын (дампуурлын үед ч гэсэн) зээлдүүлэгчдэд төлбөр хийхэд ашиглагдах боломжгүй бөгөөд доор дурдсан аль нэг тохиолдлоос бусад үед тайлагнагч байгууллагад буцаан олгогдохгүй:</p> <p>(i) Сангийн үлдэгдэл хөрөнгө нь тухайн хөтөлбөрийн эсвэл тайлагнагч байгууллагын ажилтны холбогдох бүх тэтгэмжийн үүргийг барагдуулахад хангалттай байх; эсвэл</p> <p>(ii) Ажилтны тэтгэмжийг аль хэдийн төлсөн тайлагнагч байгууллагад тэрхүү төлбөрийг нөхөн олгохын тулд хөрөнгийг уг байгууллагад буцаах.</p>	39.8

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө</b>	(а) Зээл ба авлага, (б) дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй хөрөнгө оруулалт, (в) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө гэж ангилаагүй буюу борлуулах боломжтой гэж ангилсан үүсмэл бус санхүүгийн хөрөнгө.	29.10
<b>эх ургамал</b>	Дараах амьд ургамлыг хэлнэ:  (а) Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглагддаг;  (б) Нэгээс дээш тайлант үеийн хувьд бүтээгдэхүүн өгөхөөр хүлээгдэж буй; ба  (в) Тохиолдлын шинжтэйгээр хаягдал бүтээгдэхүүн байдлаар борлуулахаас бусад тохиолдолд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гэдэг утгаар борлуулагдах магадлал багатай.	17.13,  27.9
<b>өгөөж</b>	Бусад байгууллагууд дахь оролцооноос байгууллагын олж авсан давуу тал юм. Өгөөж нь санхүүгийн буюу санхүүгийн бус байж болно. Бусад байгууллагууд дахь уг байгууллагын оролцооны бодит үр нөлөө нь эерэг эсвэл сөрөг төлөв байдалтай байж болно.	35.14
<b>заавал биелүүлэх хэлцэл (үйлчилгээний концессын хэлцлийн хувьд)</b>	Хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адилтгах эрх, үүргийг бий болгодог гэрээ болон бусад хэлцлийг илэрхийлнэ.	32.8
<b>заавал биелүүлэх хэлцэл (хамтын хэлэлцээрийн хувьд)</b>	Хэрэв гэрээний хэлбэртэй байсан бол талуудад хүлээлгэх эрх, үүрэгтэй адил хууль ёсны хүчин төгөлдөр эрх, үүргийг бий болгодог хэлцэл юм. Энэ нь гэрээгээр үүссэн эрх болон бусад хууль ёсны эрхийг агуулсан байдаг.	35.14
<b>биологийн хөрөнгө</b>	Амьд амьтан буюу ургамал.	27.9



ТАЙЛБАР ТОЛЬ

<b>Нэр томъёо</b>	<b>Тодорхойлолт</b>	<b>Байршил</b>
<b>биологийн хувьсал</b>	Биологийн хөрөнгөнд тоон буюу чанарын өөрчлөлт гарахад хүргэх өсөлт, хөгшрөлт, үйлдвэрлэл, нөхөн үржлийн үйл явц.	27.9
<b>зээлийн өртөг</b>	Мөнгө санг зээлдэн авахтай холбоотойгоор байгууллагын гаргах хүүний болон бусад зардал.	5.5
<b>төсвийн суурь</b>	Хууль тогтоогч байгууллагаас баталсан тухайн төсөвт мөрддөг нягтлан бодох бүртгэлийн аккрузл, мөнгөн буюу бусад суурь.	24.7
<b>дансны үнэ (биет бус хөрөнгийн)</b>	Аливаа хуримтлагдсан хорогдуулга ба хуримтлагдсан үнэ цэнэ бууралтын гарзыг хассаны дараа, хөрөнгийг хүлээн зөвшөөрч байгаа дүн.	31.16
<b>дансны үнэ (хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн)</b>	Хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг дүн.	16.7
<b>дансны үнэ (үндсэн хөрөнгийн)</b>	Аливаа хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнэ бууралтын гарзыг хассаны дараах хөрөнгийг хүлээн зөвшөөрч байгаа дүн.	17.13
<b>өр төлбөрийн дансны үнэ</b>	Өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч байгаа дүн.	10.7
<b>хөрөнгийн дансны үнэ</b>	Аливаа хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнэ бууралтын гарзыг хассаны дараах тухайн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч байгаа дүн.	10.7
<b>мөнгө</b>	Бэлэн мөнгө ба харилцах данснаас бүрдэнэ.	2.8
<b>мөнгөтэй адилтгах хөрөнгө</b>	Үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, ихээхэн өндөр хөрвөх чадвартай хөрөнгө оруулалт.	2.8
<b>мөнгөн гүйлгээ</b>	Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн орлогын болон зарлагын урсгал.	2.8
<b>мөнгө бий болгогч хөрөнгө</b>	Худалдаа арилжааны өгөөж бий болгох үндсэн зорилготойгоор эзэмшиж буй хөрөнгө.	21.14

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>мөнгө бий болгогч нэгж</b>	Бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогын гүйлгээнээс бүрэн хамааралгүй, тасралтгүй ашиглалтын явцад мөнгөн орлогын гүйлгээг бий болгодог бөгөөд арилжааны өгөөж бий болгох үндсэн зорилготойгоор эзэмшиж буй хөрөнгүүдийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг.	26.13
<b>нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт</b>	Хөрөнгө, өр төлбөрийн одоогийн төлөв байдлын, түүнчлэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотойгоор хүлээгдэж буй ирээдүйн өгөөж, үүргийн талаархи үнэлгээний үр дүнд тухайн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд эсвэл хөрөнгийн үечилсэн хэрэглээ зарцуулалтын дүнд хийх тохируулга. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт нь шинэ мэдээлэл буюу шинэ хөгжил дэвшлээс бий болдог, иймээс алдааны залруулга биш юм.	3.7
<b>үндсэн хөрөнгийн анги</b>	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдлын хувьд ижил төсөөтэй шинж төрөл, чиг үүрэгтэй бөгөөд санхүүгийн тайланд толилуулах зорилгоор нэг ганц зүйл байдлаар харуулдаг хөрөнгүүдийн бүлэг.	17.13
<b>хувь хүний гэр бүлийн ойрын гишүүд</b>	Хувь хүний гэр бүлийн ойрын гишүүд гэдэг нь уг байгууллагатай тэдгээрийн холбогдох ажил хэргийн харилцааны явцад тэрхүү хувь хүнд нөлөө үзүүлэх эсвэл тэр хувь хүний нөлөөнд орохоор хүлээгдэж буй гэр бүлийн гишүүд буюу ойрын төрөл садангийн хүмүүс юм.	20.4
<b>хаалтын ханш</b>	Тайлант үеийн эцэс дэх спот ханш.	4.10
<b>нэгдэгч үйл ажиллагаа</b>	Нийлүүлэлтээр үр дүнгийн байгууллагыг үүсгэн бий болгохын тулд нэг буюу хэд хэдэн өөр үйл ажиллагаануудыг нэгтгэдэг үйл ажиллагаа.	40.5

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>түрээсийн хугацааны эхлэлийн өдөр</b>	Тухайн түрээслэсэн хөрөнгөө ашиглах өөрийн эрхийг түрээслэгч хэрэгжүүлэх боломжтой болсон өдөр. Энэ нь түрээсийн анхны хүлээн зөвшөөрөлтийн (өөрөөр хэлбэл, түрээсээс үүсэх хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг тохиромжтой байдлаар хүлээн зөвшөөрөх) өдөр юм.	13.8
<b>зэрэгцүүлэгдэх суурь</b>	Тухайн нэг байгууллагуудын хувьд уг батлагдсан төсөвтэй ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн суурь болон нэг ижил ангиллын сууриар толилуулсан гүйцэтгэлийн дүн.	24.7
<b>нийгмийн хамгааллын холимог хөтөлбөр</b>	Хууль тогтоомжоор тогтоосон бөгөөд дараах шинж чанартай хөтөлбөрүүд: (а) Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгохын тулд олон-ажил олгогчийн хөтөлбөр байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг; түүнчлэн (б) Ажилтнуудын үзүүлсэн үйлчилгээний хариу төлбөр биш, тийм тэтгэмжийг олгодог.	25.10
<b>шилжүүлсэн хөрөнгийн нөхцөл</b>	Тухайн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг шилжүүлэн авагч нь тусгайлан заасны дагуу зарцуулах шаардлагатай, эсвэл уг ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тэрхүү шилжүүлэгчид буцаан өгөх ёстой гэж тусгайлан заасан болзол.	23.7
<b>нэгтгэсэн санхүүгийн тайлан</b>	Хяналт тавигч байгууллага болон түүний хяналтанд буй байгууллагуудын хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал, мөнгөн гүйлгээг эдийн засгийн нэг аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан мэтээр толилуулдаг эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайлан.	34.6

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
барилгын гэрээ	Тухайн нэг хөрөнгө эсвэл зураг төсөл, технологи, чиг үүрэг, эцсийн зорилго буюу ашиглалтын хувьд хоорондоо нягт уялдаатай, бие биенээсээ хамааралтай хөрөнгүүдийн нэгдлийг барьж байгуулахын тулд тусгайлан тохиролцсон, гэрээ буюу адилтгах заавал биелүүлэх хэлцэл.	11.4
гэрээний бус үүрэг	<p>Дараах тохиолдолд байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үүсдэг үүрэг юм:</p> <p>(а) Өнгөрсөн практикын тогтсон хэв маяг, хэвлэн нийтэлсэн бодлого буюу хангалттай тодорхой заасан одоогийн мэдэгдлээр тухайн байгууллага нь зарим хариуцлагыг хүлээнэ гэдгээ бусад талуудад илэрхийлсэн байх; ба</p> <p>(б) Үүний үр дүнд, уг байгууллага нь тэдгээр хариуцлагыг биелүүлнэ гэсэн бодит хүлээлтийг нөгөө талдаа бий болгосон байх.</p>	19.18
болзошгүй хөрөнгө	Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг бөгөөд түүний оршин байдал нь бүхэлдээ уг байгууллагын хянах боломжгүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын тохиолдолт эсвэл үл тохиолдолтоор зөвхөн батлагдах боломжит хөрөнгө.	19.18
болзошгүй төлбөр	Тусгайлан тохиролцсон ирээдүйн үйл явдал гарч тохиолдох буюу нөхцөл хангагдвал уг худалдан авсан үйл ажиллагааны хяналтыг авах арилжааны нэг хэсэг байдлаар тэрхүү худалдан авсан үйл ажиллагааны хуучин эздэд нэмэлт хөрөнгө буюу өмчийн хувь оролцоог ихэвчлэн шилжүүлэх нэгтгэгчийн үүрэг. Гэхдээ болзошгүй төлбөр нь хэрэв тусгайлан тохиролцсон нөхцөл хангагдвал өмнө шилжүүлсэн төлбөрийг буцаан авах эрхийг нэгтгэгчид мөн олгож болох юм.	40.5

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>болзошгүй өр төлбөр</b>	<p>(а) Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг бөгөөд түүний оршин байдал нь бүхэлдээ уг байгууллагын хянах боломжгүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын тохиолдолд эсвэл үл тохиолдолтоор зөвхөн батлагдах боломжит үүрэг; эсвэл</p> <p>(б) Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг боловч дараах шалтгааны улмаас хүлээн зөвшөөрөөгүй одоогийн үүрэг:</p> <p>(i) Уг үүргийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах магадлалгүй; эсвэл</p> <p>(ii) Үүргийн дүнг хангалттай найдвартай хэмжих боломжгүй.</p>	19.18
<b>болзошгүй түрээс</b>	<p>Дүнгийн хувьд тогтмол боловч цаг хугацаа урсан өнгөрөлтөөс өөр бусад байдлаар өөрчлөгдөх хүчин зүйлийн ирээдүйн дүнд (жишээлбэл; ирээдүйн борлуулалтын хувийн жин, ирээдүйн ашиглалтын дүн, ирээдүйн үнийн индекс, хүүний зах зээлийн ирээдүйн хувь хэмжээ) үндэслэдэг түрээсийн төлбөрийн тэрхүү хэсэг.</p>	13.8
<b>гэрээ гүйцэтгэгч</b>	<p>Барилгын гэрээний дагуу барилгын ажлыг гүйцэтгэдэг байгууллага.</p>	11.4

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>эздийн оруулсан хувь оролцоо</b>	<p>Гаднын талуудаас тухайн байгууллагад өр төлбөр үүсгэхээс бусад байдлаар түүнд оруулсан ба уг байгууллагын цэвэр хөрөнгө/өмч дэх санхүүгийн хувь оролцоог тогтоодог, ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи юм. Энэ нь:</p> <p>(а) дараах зүйлсийн аль алинаас авах эрхийг олгодог: (i) тухайн эзэд буюу тэдний төлөөлөгчдийн саналаар, уг байгууллага өөрийн үйл ажиллагааны явцад хийх ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн хуваарилалт, (ii) уг байгууллага татан буугдах тохиолдолд түүний өр төлбөрөөс давсан аливаа хөрөнгийн хуваарилалт; ба/буюу</p> <p>(б) борлуулах, солилцох, шилжүүлэх буюу эргэлтээс гаргах боломжтой байна.</p>	1.7
<b>хяналт</b>	<p>Байгууллага нь бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй бөгөөд уг бусад байгууллага дахь бүрэн эрхээрээ дамжуулан тэдгээр өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэх чадвар, боломжтой бол тухайн байгууллага нь тэрхүү бусад байгууллагыг хянаана.</p>	2.8
<b>хөрөнгийн хяналт</b>	<p>Байгууллага нь өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ тухайн хөрөнгийг ашиглах буюу өөр бусад байдлаар түүнээс өгөөж хүртэж чаддаг ба тэрхүү өгөөжийг бусад этгээд хүртэхийг хязгаарлах буюу бусад байдлаар зохицуулдаг тохиолдолд хөрөнгийн хяналт үүсдэг.</p>	23.7
<b>хяналтанд буй байгууллага</b>	<p>Өөр байгууллагын хяналтанд байдаг байгууллага.</p>	35.14
<b>хяналт тавигч байгууллага</b>	<p>Нэг буюу хэд хэдэн байгууллагыг хянадаг байгууллага.</p>	35.14

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
өртөг	Хөрөнгийг олж эзэмшихийн тулд түүнийг худалдан авах эсвэл барьж байгуулах хугацаанд төлсөн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүн буюу өгсөн бусад зүйлсийн бодит үнэ цэнэ.	16.7
өртөг нэмэх буюу өртөгт суурилсан гэрээ	Зөвшөөрөгдөх буюу өөр бусад байдлаар тодорхойлсон өртөг зардлыг, түүнчлэн арилжаанд суурилсан гэрээний хувьд эдгээр өртөг буюу тогтмол хөлсөн дээр хэрэв байгаа бол аливаа нэмэлт хувь хэмжээг уг гэрээ гүйцэтгэгчид нөхөн олгох барилгын гэрээ.	11.4
данснаас хасах зардал	Хөрөнгийн данснаас хасалтанд шууд хамаарах, өсөн нэмэгдэх зардал бөгөөд үүнд санхүүгийн зардал болон орлогын албан татварын зардал хамаарахгүй.	21.14
борлуулах зардал	Хөрөнгийн данснаас хасалтанд шууд хамаарах өсөн нэмэгдсэн зардал бөгөөд үүнд санхүүгийн зардал ба орлогын татварын зардал хамаарахгүй. Борлуулалтаар, эсвэл үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэй түгээн хуваарилалтаар дамжуулан данснаас хасалтыг хийж болох юм.	27.9
зээлийн эрсдэл	Санхүүгийн хэрэглүүрийн оролцогч нэг тал нь үүргээ биелүүлээгүйн улмаас оролцогч нөгөө талдаа санхүүгийн хохирол учруулах эрсдэл.	30.8
валютын эрсдэл	Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл.	30.8

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>одоогийн орлуулалтын өртөг</b>	Тайлангийн өдрөөр тухайн хөрөнгийг олж эзэмшихийн тулд байгууллагын зарцуулах байсан өртөг.	12.9
<b>одоогийн үйлчилгээний зардал</b>	Тухайн тайлант үед ажилтны үзүүлсэн үйлчилгээний үр дүн болох тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийн өсөлт.	25.10
<b>УСНББОУС-ыг мөрдсөн өдөр</b>	Байгууллага аккруэл суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдсөн өдөр, түүнчлэн уг анх удаа мөрдөж буй байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн болон шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг, эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг толилуулсан тайлант үеийн эхлэл.	33.9
<b>шийдвэр гаргагч</b>	Шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, ба энэ нь үндсэн оролцогч эсвэл бусад талуудын төлөөлөн оролцогч байна.	35.14
<b>төсөөлөн тооцсон өртөг</b>	Тогтоосон өдрөөрх худалдан авалтын өртөг эсвэл элэгдэл тооцсон өртгийн хувьд түүний орлуулагч болгон ашигладаг дүнг хэлнэ.	33.9
<b>дутагдал эсвэл илүүдэл</b>	(а) Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнээс (б) Уг хөтөлбөрийн хөрөнгө (хэрэв байгаа бол)-ийн бодит үнэ цэнийг хассан дүнг хэлнэ.	39.8
<b>тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр</b> 2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.	Тогтоосон шимтгэлийн хөтөлбөрөөс бусад, ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр.	25.10
<b>тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр</b> 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.	Тогтоосон шимтгэлийн хөтөлбөрөөс бусад, ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр.	39.8



ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<p><b>тогтоосон шимтгэлийн хөтөлбөр</b></p> <p>2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.</p>	<p>Ажил олгогч-байгууллага шимтгэлийг өөр тусдаа байгууллагад (сан)-д тогтмол дүнгээр төлөх бөгөөд ажилтны тухайн тайлант үед болон өмнөх тайлант үеүдэд үзүүлсэн үйлчилгээтэй холбоотойгоор тэрхүү ажилтны бүх тэтгэмжийг төлөхөд уг сан хангалттай хөрөнгөгүй байлаа гэхэд тухайн ажил олгогч-байгууллага цаашид нэмэлт шимтгэл төлөх хуулийн эсвэл гэрээний бус үүрэг хүлээдэггүй тийм ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр юм.</p>	25.10
<p><b>тогтоосон шимтгэлийн хөтөлбөр</b></p> <p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>	<p>Ажил олгогч-байгууллага шимтгэлийг өөр тусдаа байгууллагад (сан)-д тогтмол дүнгээр төлөх бөгөөд ажилтны тухайн тайлант үед болон өмнөх тайлант үеүдэд үзүүлсэн үйлчилгээтэй холбоотойгоор тэрхүү ажилтны бүх тэтгэмжийг төлөхөд уг сан хангалттай хөрөнгөгүй байлаа гэхэд тухайн ажил олгогч-байгууллага цаашид нэмэлт шимтгэл төлөх хуулийн эсвэл гэрээний бус үүрэг хүлээдэггүй тийм ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр юм.</p>	39.8
<b>элэгдүүлэх дүн</b>	<p>Хөрөнгийн өртгөөс эсвэл өртгийг орлох бусад дүнгээс түүний үлдэх өртгийг хассан дүн.</p>	17.13
<b>элэгдэл</b>	<p>Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт.</p>	17.13
<b>үл хүлээн зөвшөөрөлт</b>	<p>Өмнө хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайлангаас хасалт.</p>	29.10

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо үүсмэл хэрэглүүр	Тодорхойлолт	Байршил
	<p>[УСНББОУС 29]-ийн цар хүрээнд хамаарах (2-6-р параграфыг үзнэ үү) бөгөөд дараах бүх гурван шинж чанар бүхий санхүүгийн хэрэглүүр буюу бусад гэрээ:</p> <p>(а) Тохиролцсон хүүний хувь, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индекс, зээлийн зэрэглэл буюу зээлийн индекс, түүнчлэн уг гэрээний аль нэг талд тусгайлан хамаарахгүй санхүүгийн бус хувьсагч гэх мэт бусад хувьсагчдын (зарим үед 'суурь зүйл' гэж нэрлэдэг) өөрчлөлтийн хариу болгон түүний үнэ цэнэ өөрчлөгддөг.</p> <p>(б) Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг.</p> <p>(в) Ирээдүйн өдөр барагдуулдаг.</p>	29.10
<b>хөгжүүлэлт</b>	<p>Шинэ буюу мэдэгдэхүйц сайжруулсан материал, төхөөрөмж, бүтээгдэхүүн, процесс, системийн үйлдвэрлэл эсвэл үйлчилгээний төлөвлөлт, зохиомжинд судалгааны үр дүн болон бусад мэдлэгийг, тэдгээрийн арилжааны зорилготой үйлдвэрлэл, ашиглалт эхлэхээс өмнө хэрэглэх үйл ажиллагаа.</p>	31.16
<b>эздэд олгосон хуваарилалт</b>	<p>Тухайн байгууллага өөрийн бүх буюу зарим эздэд хөрөнгө оруулалтын өгөөж эсвэл хөрөнгө оруулалтын буцаалт хэлбэрээр хуваарилсан ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи.</p>	1.7
<b>эдийн засгийн нэгдмэл байгууллага</b>	<p>Хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй байгууллагууд.</p>	1.7, 35.14

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
эдийн засгийн ашиглалтын хугацаа	Дараах зүйлсийн аль нэг нь байна: (а) Нэг буюу хэд хэдэн хэрэглэгчдэд тухайн хөрөнгө нь эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болгохоор хүлээгдэж буй хугацаа; эсвэл (б) Нэг буюу хэд хэдэн хэрэглэгч нар нь тухайн хөрөнгөөс олж авахаар хүлээгдэж буй бүтээгдэхүүн буюу түүнтэй ижилт төсөөтэй нэгжүүдийн тоо хэмжээ.	13.8

**Нэр томъёо**  
**үр ашигт хүүний**  
**арга**

**Тодорхойлолт**

Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн (санхүүгийн хөрөнгүүд болон санхүүгийн өр төлбөрүүдийн бүлгийн) хорогдуулсан өртгийг тооцоолох ба хүүний орлого буюу хүүний зардлыг холбогдох тайлант үед хуваарилах арга. Үр ашигт хүүний хувь гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны туршид буюу тохиромжтой бол үүнээс богино хугацаанд тооцоолсон ирээдүйн мөнгөн төлбөр эсвэл мөнгөн орлогыг тухайн санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн цэвэр дансны үнэ хүртэл яг нарийн дискаунтчилдаг хүүний хувь юм. Үр ашигт хүүний хувийг тооцоолохдоо байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцлүүдийг (тухайлбал; урьдчилан төлөлт, дуудах опцион ба үүнтэй ижил төсөөтэй опцион) харгалзан үзсэнээр уг хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тооцоолох боловч ирээдүйн зээлийн алдагдлыг харгалзан үзэхгүй. Гэрээний талуудын хооронд төлсөн эсвэл хүлээн авсан, уг үр ашигт хүүний хувийн салшгүй хэсэг болох бүх хураамж ба оноо (УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ыг үзнэ үү), ажил гүйлгээний зардал, бусад бүх урамшуулал буюу хөнгөлөлт нь энэхүү тооцоололд хамаарна. Ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн мөнгөн гүйлгээ ба тэдгээрийн хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолж чадна гэсэн урьдчилсан нөхцөлтэй байдаг. Гэвч санхүүгийн хэрэглүүрийн (санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) мөнгөн гүйлгээ эсвэл хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолох боломжгүй тийм цөөн ховор тохиолдолд байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн (санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) нийт гэрээний хугацаан дахь уг гэрээний мөнгөн гүйлгээг харгалзан үзнэ.

**Байршил**

29.10

ТАЙЛБАР ТОЛЬ

<b>Нэр томъёо</b>	<b>Тодорхойлолт</b>	<b>Байршил</b>
<b>ажилтны тэтгэмж</b> 2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.	Ажилтнуудын үзүүлсэн үйлчилгээний хариуд байгууллагаас олгож буй бүх бүх төрлийн төлбөр.	25.10
<b>ажилтны тэтгэмж</b> 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.	Ажилтнуудын үзүүлсэн үйлчилгээний хариуд буюу ажлаас халагдалтын хувьд байгууллагаас олгож буй бүх бүх төрлийн төлбөр буюу урамшуулал.	39.8

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>байгууллагын тусгайлсан үнэ цэнэ</b>	Хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас болон түүний ашиглалтын хугацааны эцэс дэх данснаас хасалтаас үүсэхээр эсвэл өр төлбөрийг барагдуулах үед зарцуулахаар уг байгууллагын хүлээж буй мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ юм.	17.13
<b>өмчийн хувь оролцоо</b>	Энэ Стандартын зорилгын хувьд, хөрөнгө оруулагчийн өмчилдөг байгууллагуудын өмчлөлийн хувь оролцоо болон хамтын байгууллагын эзэн, гишүүн буюу оролцогчийн хувь оролцоог илэрхийлэхийн тулд өмчийн хувь оролцоог өргөн утгатайгаар ашигладаг.	40.5
<b>өмчийн хэрэглүүр</b>	Бүх өр төлбөрийг хассаны дараа байгууллагын хөрөнгөнд үлдэх хувь оролцоог илэрхийлэх аливаа гэрээ.	28.9
<b>өмчийн арга (бусад байгууллагууд дахь хувь оролцоотой холбоотой)</b>	Хөрөнгө оруулалтыг эхлээд өртгөөр хүлээн зөвшөөрөх ба үүний дараа уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн санхүүжигчийн цэвэр хөрөнгө/өмч дэх тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоонд тэрхүү худалдан авалтаас хойш гарсан өөрчлөлтийн хувьд тохируулга хийдэг нягтлан бодох бүртгэлийн арга юм. Хөрөнгө оруулагчийн ашиг, алдагдал нь санхүүжигчийн ашиг, алдагдалд өөрийн эзлэх хувь хэмжээг агуулсан байх бөгөөд тухайн хөрөнгө оруулагчийн цэвэр хөрөнгө/өмч нь уг санхүүжигчийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөөгүй тэрхүү санхүүжигчийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтөд өөрийн эзлэх хувь хэмжээг агуулсан байна.	36.8

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>тайлангийн өдрийн дараах үйл явдал</b>	<p>Тайлангийн өдөр ба санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрийн хооронд гарч тохиолдсон тааламжтай болон тааламжгүй үйл явдлууд юм. Дараах хоёр төрлийн үйл явдлыг тодорхойлж болно:</p> <p>(а) Тайлангийн өдрөөр оршин байсан нөхцөл байдлуудыг батлан илэрхийлэх үйл явдал (тайлангийн өдрийн дараах залруулагдах үйл явдал); ба</p> <p>(б) Тайлангийн өдрийн дараа үүссэн нөхцөл байдлуудыг илэрхийлэх үйл явдал (тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдал).</p>	14.5
<b>ханшийн зөрүү</b>	Тодорхой тооны нэг валютыг нөгөө валютанд өөр өөр ханшаар хөрвүүлснээс үүссэн зөрүү.	4.10
<b>валютын ханш</b>	Хоёр валютын хоорондох солилцооны харьцаа.	4.10
<b>арилжааны ажил гүйлгээ</b>	Нэг байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах, эсвэл өр төлбөрийг барагдуулах ба үүний хариуд ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлсийг (үндсэндээ мөнгө, бараа, үйлчилгээ буюу хөрөнгө ашиглуулах хэлбэрээр) нөгөө талд шууд өгдөг ажил гүйлгээг хэлнэ.	9.11
<b>бүрэн биелэгдээгүй гэрээ</b>	Аль нэг тал өөрийн ямар нэг үүргийг биелүүлээгүй эсвэл хоёр талын аль аль нь өөрсдийн үүргийг адил тэнцүү хэмжээгээр хэсэгчлэн биелүүлсэн гэрээ.	19.18
<b>зардал</b>	Эздэд олгосон хуваарилалттай холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчийг багасгах үр дүн бүхий хөрөнгийн зарлагын гүйлгээ буюу хорогдон багасалт, эсвэл өр төлбөр үүсэлт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралт.	1.7
<b>татварын системээр дамжуулан төлсөн зардал</b>	Үр шим хүртэгч нь татвар төлсөн эсэхээс үл хамааран түүнд олгогдох дүн.	23.7

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>бодит үнэ цэнэ</b>	Холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгийг арилжих буюу өр төлбөрийг барагдуулж болох дүн.	9.11
<b>борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ</b>	Зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох, харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийг борлуулснаар олж авах ба түүний данснаас хасалтын зардлыг хассаны дараах дүн юм.	21.14
<b>тодотгосон төсөв</b>	Тухайн төсвийн хугацаанд хамаарах бүх нөөц, өмнөх үеэс шилжиж ирсэн дүн, шилжүүлэг, хуваарилалт, нэмэлт төсвийн хуваарилалт болон бусад зөвшөөрөгдсөн хууль тогтоомжийн буюу адилтгах бүрэн эрхийн дагуу хийгдсэн өөрчлөлтийн хувьд тохируулга хийсэн анхны төсөв юм.	24.7
<b>санхүүгийн түрээс</b>	Хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэг түрээс. Өмчлөлийн эрх нь аажмаар шилждэг эсвэл шилждэггүй байж болно.	13.8



ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
санхүүгийн хөрөнгө	<p data-bbox="467 249 817 272">Дараах аливаа хөрөнгө юм:</p> <ul style="list-style-type: none"><li data-bbox="467 297 626 319">(a) Мөнгө;</li><li data-bbox="467 344 1009 367">(б) Өөр байгууллагын өмчийн хэрэглүүр;</li><li data-bbox="467 392 794 415">(в) Доорх гэрээний эрх:<ul style="list-style-type: none"><li data-bbox="538 439 1018 519">(i) Өөр байгууллагаас мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авах; эсвэл</li><li data-bbox="538 544 1018 691">(ii) Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагад тааламжтай байх нөхцлөөр өөр байгууллагатай солилцох; эсвэл</li></ul></li><li data-bbox="467 715 1018 795">(г) Тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах буюу барагдуулж болох гэрээ ба үүнд:<ul style="list-style-type: none"><li data-bbox="538 820 1018 995">(i) Уг байгууллага нь өөрийн өмчийн хэрэглүүрийг тогтмол бус тоо ширхэгээр хүлээн авах үүрэг хүлээсэн буюу хүлээж болох үүсмэл бус хэрэглүүр; эсвэл</li><li data-bbox="538 1020 1018 1700">(ii) Тухайн байгууллагын тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийн хариуд тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг солилцохоос бусад байдлаар барагдуулах буюу барагдуулж болох үүсмэл хэрэглүүр. Энэ зорилгын хувьд тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрт дараах зүйлс хамаарахгүй: 15 ба 16-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр; тухайн байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг уг байгууллагад хүлээлгэдэг бөгөөд 17, 18-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж</li></ul></li></ul>	28.9

ангилсан хэрэглүүр; тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг ирээдүйд хүлээн авах эсвэл өгөх тийм гэрээ болох хэрэглүүр.

**ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр**

Дараах нөхцлүүдийн аль нэгийг хангадаг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр юм: 29.10

(а) Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилдаг. Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилна:

(i) Ойрын хугацаанд худалдан борлуулах эсвэл буцаан худалдан авах зорилготойгоор үндсэндээ олж эзэмшсэн буюу гаргасан;

(ii) Анх хүлээн зөвшөөрөх үед, хамтад нь удирдан зохицуулдаг бөгөөд богино хугацаанд ашиг олох зорилготой гэсэн нотолгоо бүхий тодорхой санхүүгийн хэрэглүүрийн багцын нэг хэсэг байх;

(iii) Үүсмэл хэрэглүүр байх (санхүүгийн баталгааны гэрээ эсвэл сонгосон ба үр дүнтэй хейжийн хэрэглүүр болох үүсмэл хэрэглүүрээс бусад).

(б) Анх хүлээн зөвшөөрөх үед тухайн байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан. Байгууллага нь зөвхөн 13-р параграфтаар зөвшөөрсөн тохиолдолд эсвэл дараах шалтгааны улмаас ингэж ангилах нь илүү хамааралтай мэдээлэл бий болгох үр дүнтэй тохиолдолд ийм ангиллыг ашиглаж болно:

(i) Энэ нь хөрөнгө, өр төлбөрийг өөр сууриудаар хэмжсэнээр эсвэл тэдгээрийн олз, гарзыг өөр сууриудаар хүлээн

зөвшөөрснөөр үүсэх байсан хэмжилтийн болон хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг (зарим үед “нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал” гэж нэрлэдэг) арилгах буюу мэдэгдэхүйц бууруулдаг; эсвэл

- (ii) Санхүүгийн хөрөнгүүдийн, санхүүгийн өр төлбөрүүдийн бүлэг эсвэл эдгээрийн аль алины бүлгийг тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын болон хөрөнгө оруулалтын баримтжуулсан стратегийн дагуу удирдаж, түүний гүйцэтгэлийг бодит үнэ цэнийн сууриар үнэлдэг бөгөөд тэрхүү бүлгийн талаархи мэдээллийг уг байгууллагын эрх бүхий албан тушаалтанд (УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-д тодорхойлсон), тухайлбал, байгууллагын удирдах зөвлөл ба гүйцэтгэх захиралд дотооддоо танилцуулдаг.

**санхүүгийн  
баталгааны гэрээ**

Өрийн хэрэглүүрийн анхны буюу засварлан өөрчилсөн нөхцлийн дагуу төлөх ёстой төлбөрөө тухайн зээлдэгч барагдуулаагүйн улмаас учирсан алдагдлын хувьд уг гэрээг эзэмшигчид нөхөн төлбөр болгон тодорхой төлбөр төлөхийг түүний гаргагчаас шаарддаг гэрээ.

29.10

ТАЙЛБАР ТОЛЬ

<b>Нэр томъёо</b>	<b>Тодорхойлолт</b>	<b>Байршил</b>
<b>санхүүгийн хэрэглүүр</b>	Нэг байгууллагын хувьд санхүүгийн хөрөнгө, нөгөө байгууллагын хувьд санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр үүсэхэд хүргэдэг аливаа гэрээ.	28.9
<b>санхүүгийн өр төлбөр</b>	<p>Дараах аливаа өр төлбөр юм:</p> <p>(а) Доорх гэрээний үүрэг:</p> <p>(i) Өөр байгууллагад мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх; эсвэл</p> <p>(ii) Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагад тааламжгүй байх нөхцлөөр өөр байгууллагатай солилцох; эсвэл</p> <p>(б) Тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах буюу барагдуулж болох гэрээ ба үүнд:</p> <p>(i) Уг байгууллага нь өөрийн өмчийн хэрэглүүрийг тогтмол бус тоо ширхэгээр өгөх үүрэг хүлээсэн буюу хүлээж болох үүсмэл бус хэрэглүүр; эсвэл</p> <p>(ii) Тухайн байгууллагын тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийн хариуд тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг солилцохоос бусад байдлаар барагдуулах буюу барагдуулж болох үүсмэл хэрэглүүр. Энэ зорилгын хувьд тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрт дараах зүйлс хамаарахгүй: 15 ба 16-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр; тухайн байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг уг байгууллагад хүлээлгэдэг бөгөөд 17, 18-р параграфын</p>	28.9

## ТАЙЛБАР ТОЛЬ

дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүр; тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг ирээдүйд хүлээн авах эсвэл өгөх тийм гэрээ болох хэрэглүүр.

Хэрэв санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангах хэрэглүүр нь 15, 16-р параграфт эсвэл 17, 18-р параграфт заасан бүх шинжүүдтэй ба нөхцлүүдийг хангаж байвал гажих тохиолдол болгон уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж ангилна.

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>санхүүгийн үйл ажиллагаа</b>	Байгууллагын хувь нийлүүлсэн капитал ба зээлийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах үр дүн бүхий үйл ажиллагаа.	2.8
<b>торгууль</b>	Хууль буюу зохицуулалтыг зөрчсөний үр дагавар болгон шүүх эсвэл хуулийг хэрэгжүүлэгч бусад этгээдийн тодорхойлсны дагуу улсын секторын байгууллагууд хүлээн авсан эсвэл хүлээн авахаар болсон эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи.	23.7
<b>арилжааны баталгаа</b>	Ирээдүйн товлосон өдөр, тогтоосон үнээр, тодорхой хэмжээний нөөцийг солилцох заавал биелүүлэх хэлцэл.	29.10
<b>УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан</b>	Тухайн санхүүгийн тайлангийн үнэн зөв толилуулга, түүнчлэн аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх түүний чадвар боломжид нөлөөлөхгүй, энэ Стандартад заасан шилжилтийн үеийн нэг буюу хэд хэдэн чөлөөлөх нөхцлүүдийг мөрдсөний үр дүнд байгууллага УСНББОУС-тай нийцсэн талаар бүрэн тодорхой мэдэгдэл гаргаж чадах ба аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн анхны, жилийн санхүүгийн тайлан.	33.9
<b>анх удаа мөрдөж буй байгууллага</b>	Аккруэл суурьт УСНББОУС-ыг анх удаа мөрдөж байгаа ба шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг, эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланг толилуулж буй байгууллага.	33.9
<b>тогтмол үнэтэй гэрээ</b>	Гэрээний тогтмол үнийг эсвэл гарцын нэгж тутамд тогтмол төлбөр төлөхийг тухайн гэрээ гүйцэтгэгч зөвшөөрсөн бөгөөд зарим тохиолдолд өртөг нэмэгдүүлэх заалт бүхий барилгын гэрээ.	11.4
<b>урьдчилан таамагласан ажил гүйлгээ</b>	Баталгаа гаргаагүй боловч урьдчилан төсөөлсөн ирээдүйн ажил гүйлгээ.	29.10
<b>гадаад валют</b>	Байгууллагын бүртгэлийн валютаас өөр валют юм.	4.10

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
гадаад үйл ажиллагаа	Тайлагнагч байгууллагын улс орон буюу валютаас өөр улс орон буюу валютанд үндэслэн үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг уг тайлагнагч байгууллагын хяналтанд буй байгууллага, хараат компани, хамтын хэлэлцээр эсвэл салбар.	4.10
бүртгэлийн валют	Тухайн байгууллага үйл ажиллагаагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны валют.	4.10
засгийн газрын үндсэн сектор	Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудад тодорхойлсон, төв засгийн газрын бүтэц зохион байгуулалтанд хамаарах бүх байгууллагуудаас бүрдэнэ.	22.15
гүүдвил	Худалдан авалтаар олж эзэмшсэн бусад хөрөнгүүдээс үүсдэг бөгөөд бие даасан байдлаар тодорхойлж, тусад нь хүлээн зөвшөөрдөггүй ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлэх хөрөнгө.	40.5
эрх бүхий этгээд (үйлчилгээний концессын хэлцэлд)	Үйлчилгээний концессын хөрөнгийг ашиглах эрхийг эзэмшигчид олгодог байгууллага.	32.8
түрээсийн нийт хөрөнгө оруулалт	Дараах зүйлсийн нийлбэр дүн байна: (а) Санхүүгийн түрээсийн дагуу түрээслүүлэгчийн авах түрээсийн хамгийн бага төлбөрүүд; ба (б) Түрээслүүлэгчид хуримтлагдах баталгаагүй, аливаа үлдэх өртөг.	13.8
биологийн хөрөнгүүдийн бүлэг	Амьд, ижил төсөөтэй ургамал буюу амьтны нэгдэл.	27.9

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>баталгаатай үлдэх өртөг</b>	<p>(а) Түрээслэгчийн хувьд, тухайн түрээслэгч буюу уг түрээстэй холбоотой бусад талын баталгаа өгсөн үлдэх өртгийн тэрхүү хэсэг (баталгааны дүн нь аливаа тохиолдолд төлж болох хамгийн их дүн байна); ба</p> <p>(б) Түрээслүүлэгчийн хувьд, түрээслүүлэгчтэй холбоогүй бөгөөд уг баталгааны дагуу хүлээх үүргийг барагдуулах санхүүгийн чадвартай гуравдагч талаас эсвэл түрээслэгчээс баталгаа өгсөн үлдэх өртгийн тэрхүү хэсэг.</p>	13.8
<b>үр шим хүртэлт</b>	Биологийн хөрөнгөөс бүтээгдэхүүнийг салган авалт эсвэл биологийн хөрөнгийн амьдрах үйл явцын зогсоолт.	27.9
<b>хейжийн зүйл</b>	<p>(а) өөрийн бодит үнэ цэнийн эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн хувьд тухайн байгууллагыг эрсдэлд өртүүлдэг, (б) хейж хийхээр сонгосон тийм хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгаа, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалт юм (хейжийн зүйлийн тодорхойлолтыг [УСНББОУС 29]-ийн 87-94-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ131-МЗУ141-р параграфт тайлбарласан).</p>	29.10
<b>хейжийн үр дүнтэй байдал</b>	Хейж хийсэн эрсдэлд хамаарах уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтөөр нөхөх хэмжээ юм. ([УСНББОУС 29]-ийн Хавсралт А-гийн МЗУ145-МЗУ156-р параграфыг үзнэ үү).	29.10



Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
хейжийн хэрэглүүр	Сонгосон хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг өөрийн бодит үнэ цэнээр эсвэл мөнгөн гүйлгээгээр нөхөхөөр хүлээгдэж буй, сонгосон үүсмэл хэрэглүүр (зөвхөн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлийн хейжийн хувьд) эсвэл сонгосон үүсмэл бус санхүүгийн хөрөнгө, үүсмэл бус санхүүгийн өр төлбөр юм (хейжийн хэрэглүүрийн тодорхойлолтыг [УСНББОУС 29]-ийн 81-86-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ127-МЗУ130-р параграфт тайлбарласан).	29.10
дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт	<p>Тухайн байгууллага түүнийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших эерэг санаа зорилго ба чадвар боломжтой бөгөөд тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүдтэй, тогтоосон дуусгавар болох хугацаатай, доор дурдсанаас бусад, үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм ([УСНББОУС 29]-ийн Хавсралт А-гийн МЗУ29-МЗУ38-р параграфыг үзнэ үү):</p> <p>(а) Анх хүлээн зөвшөөрөх үед уг байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө;</p> <p>(б) Байгууллага нь борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгө; ба</p> <p>(в) Зээл ба авлагын тодорхойлолтыг хангадаг санхүүгийн хөрөнгө.</p>	29.10
	<p>Хэрэв байгууллага нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших, мэдэгдэхүйц бус хэмжээнээс илүү дүн (дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй хөрөнгө оруулалтын нийт дүнтэй харьцуулахад мэдэгдэхүйц бус хэмжээнээс илүү дүн) бүхий хөрөнгө оруулалтыг дараах борлуулалт буюу дахин ангиллаас өөр бусад байдлаар түүний дуусгавар болох хугацаанаас өмнө тухайн тайлант жилд болон өмнөх хоёр жилийн хугацаанд</p>	

## ТАЙЛБАР ТОЛЬ

борлуулж эсвэл дахин ангилж байсан бол уг байгууллага нь ийм аливаа санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй гэж ангилахгүй:

- (а) дуусгавар болох хугацаа буюу тухайн санхүүгийн хөрөнгийн дуудах өдөртэй маш ойрхон (жишээлбэл; дуусгавар болох хугацаа хүртэл гурван сараас богино хугацаатай), ингэснээр хүүний зах зээлийн түвшний өөрчлөлт нь уг санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээргүй байх;
- (б) Байгууллага нь хуваарьт төлбөрүүд буюу урьдчилсан төлбөрөөр тухайн санхүүгийн хөрөнгийн бараг бүх анхны үндсэн дүнг цуглуулсны дараа хийгдсэн; эсвэл
- (в) Тухайн байгууллагын хяналтанд хамаарахгүй, дахин үл давтагдах ба уг байгууллага ул үндэслэлтэйгээр урьдчилан таамаглаж чадахгүй тусдаа үйл явдалд хамаарах.

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
тодорхойлогдох	Дараах аль нэг тохиолдолд хөрөнгө нь тодорхойлогдох боломжтой байна:	40.5
	(а) Салган тусгаарлаж болох, өөрөөр хэлбэл байгууллага нь ингэх санаа бодолтой эсэхээс үл хамааран тухайн байгууллагаас тусгаарлах буюу хуваах ба дангаар нь, эсвэл холбогдох заавал биелүүлэх хэлцэл, тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөртэй хамтад нь худалдах, шилжүүлэх, лицензээр эзэмшүүлэх, түрээслүүлэх, арилжих боломжтой байх; эсвэл	
	(б) Заавал биелүүлэх хэлцлийн эрхүүдийг (үүн дотроо, гэрээний буюу бусад хуулийн эрхийг) шилжүүлж болох, эсвэл тухайн байгууллагаас болон бусад эрх, үүргээс салган тусгаарлах боломжтой эсэхээс үл хамааран заавал биелүүлэх хэлцлээс үүсдэг байх.	
үнэ цэнийн бууралт	Хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралтыг элэгдлээр дамжуулан системтэй хүлээн зөвшөөрөх дүнгээс илүү буюу өндрөөр тухайн хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид учрах гарз юм.	21.14
мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	Хөрөнгийн дансны үнэ нь өөрийн нөхөгдөх дүнгээс давж илүү гарсан дүн.	17.13
мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	Хөрөнгийн дансны үнэ нь өөрийн нөхөгдөх дүнгээс давж илүү гарсан дүн.	17.13

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<p><b>практик боломжгүй байдал (1)</b></p>	<p>Шаардлагыг даган мөрдөх практик боломжгүй байдал гэдэг нь хэрэгжүүлэх ул үндэслэлтэй бүх хүчин чармайлтыг тухайн байгууллага гаргасан боловч даган мөрдөж чадаагүй нөхцөл байдал юм.</p>	1.7
<p><b>практик боломжгүй байдал (2)</b></p>	<p>Тухайн байгууллага нь боломжит бүх хүчин чармайлтыг гаргасан боловч даган мөрдөж чадахгүй тохиолдолд уг шаардлагыг даган мөрдөх практик боломжгүй байна. Доорх тохиолдолд өмнөх тодорхой нэг тайлант үеийн хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг буцаах горимоор мөрдөх эсвэл алдааг засварлахын тулд буцаан дахин тайлагнах практик боломжгүй байдаг:</p> <p>(а) Буцаах горимоор мөрдөлт буюу буцаан дахин тайлагналтын үр нөлөөг тодорхойлох боломжгүй;</p> <p>(б) Буцаах горимоор мөрдөлт буюу буцаан дахин тайлагналт нь тэрхүү тайлант үед удирдлагын санаа зорилго ямар байсан талаархи таамаглал хийхийг шаарддаг; эсвэл</p> <p>(в) Буцаах горимоор мөрдөлт буюу буцаан дахин тайлагналт нь дүнгүүдийн нилээд нүсэр тооцооллыг шаарддаг бөгөөд доорх тооцооллуудын талаархи мэдээллийг бодитойгоор салган зааглах боломжгүй байх:</p> <p>(i) дүнгүүдийг хүлээн зөвшөөрөх, хэмжих буюу тодруулах үед оршин байсан нөхцөл байдлын тухай нотолгоогоор хангах тооцоолол;</p> <p>(ii) тэрхүү өмнөх тайлант үеийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөх үед бусад мэдээллээс тооцон гаргаж, бэлэн байлгаж болох байсан тийм тооцоолол.</p>	3.7

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
түрээс үүссэн өдөр	<p>Түрээсийн гэрээний өдөр ба талууд уг түрээсийн үндсэн хугацаа, нөхцлийн хувьд хариуцлага хүлээсэн өдрийн аль эхэнд болох өдөр. Энэ өдрийн байдлаар:</p> <p>(а) Түрээсийг үйл ажиллагааны түрээс эсвэл санхүүгийн түрээс гэж ангилна; ба</p> <p>(б) Санхүүгийн түрээсийн хувьд, уг түрээсийн хугацааны эхлэлийн өдөр хүлээн зөвшөөрөх дүнг тодорхойлно.</p>	13.8
анхны шууд зардал	<p>Үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгчийн гаргаснаас бусад, тухайн түрээсийн хэлцэл хийх ба зохион байгуулахтай шууд холбоотой өсөн нэмэгдсэн зардлууд.</p>	13.8
биет бус хөрөнгө	<p>Биет шинж чанаргүй, тодорхойлж болох мөнгөн бус зүйлсийн хөрөнгө.</p>	31.16
хүүний зардал	<p>Тэтгэмжийг барагдуулахад нэг тайлант үеэр ойртсон учраас тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэд тухайн тайлант үед нэмэгдсэн дүн.</p>	25.10
бусад байгууллага дахь хувь оролцоо	<p>Бусад байгууллагын үр дүнгээс үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд тухайн байгууллагад эрсдэл учруулах заавал биелүүлэх хэлцлээр буюу өөр бусад байдлаар хийгдэх оролцоог илэрхийлнэ. Бусад байгууллага дахь хувь оролцоог өмчийн буюу өрийн хэрэглүүрийн эзэмшилт, түүнчлэн санхүүжилт, төлбөрийн чадварын дэмжлэг, зээлийн сайжруулалт, хөрөнгийн баталгаа олголт гэх мэт бусад хэлбэрийн оролцоогоор нотолж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй. Энэ нь бусад байгууллагыг хянах, хамтран хянах эсвэл мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх уг байгууллагын арга хэрэгслийг агуулсан байдаг. Харин байгууллага нь санхүүжүүлэгч/санхүүжигч эсвэл худалдан авагч/нийлүүлэгчийн зөвхөн нийтлэг харилцаатай байснаар уг бусад байгууллагад заавал хувь оролцоотой гэсэн үг биш юм.</p>	38.7

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>түрээсийн нуугдмал хүүний түвшин</b>	<p>Түрээс үүссэн өдрөөрх (i) тухайн түрээслэсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба (ii) түрээслүүлэгчийн аливаа анхны шууд зардлын нийлбэрийг дараах зүйлсийн нийт өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү болоход хүргэдэг дискаунтын хувь хэмжээ юм:</p> <p>(a) Түрээсийн хамгийн бага төлбөрүүд; ба</p> <p>(б) Баталгаагүй, үлдэх өртөг.</p>	13.8
<b>хүүний түвшний эрсдэл</b>	Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтийн улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл.	30.8
<b>бараа материал</b>	<p>Дараах хөрөнгүүд юм:</p> <p>(a) Үйлдвэрлэлийн процессод ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа;</p> <p>(б) Үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах буюу түгээн хуваарилагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа;</p> <p>(в) Хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулах буюу түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа;</p> <p>(г) Борлуулах буюу түгээн хуваарилахын тулд үйлдвэрлэлийн процессод байгаа.</p>	12.9

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа</b>	Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд хамаарахгүй урт хугацаат хөрөнгө ба бусад хөрөнгө оруулалтыг худалдан авах болон данснаас хасах үйл ажиллагаа.	2.8
<b>хөрөнгө оруулалтын байгууллага</b>	<p>Дараах байгууллага юм:</p> <p>(а) Нэг буюу хэд хэдэн хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор тэдгээр хөрөнгө оруулагчдаас мөнгө, санхүүжилт авдаг;</p> <p>(б) Гагцхүү капиталын үнийн өсөлт, хөрөнгө оруулалтын орлого эсвэл энэ хоёрын аль алианаас ашиг олох зорилгоор уг мөнгө сангаар хөрөнгө оруулалт хийх зорилготой байдаг; ба</p> <p>(в) Өөрийн бараг бүх хөрөнгө оруулалтын үр дүнг бодит үнэ цэнийн сууриар үнэлж, хэмждэг.</p>	35.14
<b>хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө</b>	<p>Доор дурдсан зорилгоор биш, харин түрээсийн орлогоор эсвэл капиталын үнийн өсөлтөөр, эсвэл энэ хоёрын аль алианаар ашиг олохын тулд эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө (газар, эсвэл барилга буюу барилгын нэг хэсэг, эсвэл газар, барилгын аль аль нь):</p> <p>(а) Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд эсвэл захиргаа удирдлагын зорилгоор ашиглах; эсвэл</p> <p>(б) Хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулах.</p>	16.7
<b>хамтын хэлэлцээр</b>	Хамтын хяналт бүхий хоёр буюу хэд хэдэн талуудын хоорондох хэлэлцээр.	36.8
<b>хамтын хяналт</b>	Хэлэлцээрийн хувьд заавал биелүүлэх хэлцлээр тохирсон хамтарсан хяналт бөгөөд холбогдох үйл ажиллагааны талаархи шийдвэр нь уг хамтын хяналт бүхий талуудын санал нэгтэй зөвшөөрлийг шаарддаг зөвхөн тийм тохиолдолд уг хяналт хэрэгждэг.	36.8

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>хамтын үйл ажиллагаа</b>	Хэлэлцээрт хамтын хяналт тавьдаг оролцогч талууд нь тэрхүү хэлэлцээртэй холбоотойгоор хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй байдаг хамтын хэлэлцээр.	37.7
<b>хамтын үйл ажиллагаа эрхлэгч</b>	Хамтын үйл ажиллагаанд хамтын хяналттай, уг хамтын үйл ажиллагааны оролцогч тал.	37.7
<b>хамтарсан үйлдвэр</b>	Хэлэлцээрийн хувьд хамтын хяналт бүхий талууд нь тухайн хэлэлцээрийн цэвэр хөрөнгөнд хамаарах тодорхой эрхтэй байдаг тийм хамтын хэлэлцээр.	36.8
<b>хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч</b>	Хамтарсан үйлдвэрт хамтын хяналттай, уг хамтарсан үйлдвэрийн оролцогч тал.	36.8
<b>эрх бүхий албан тушаалтан</b>	<p data-bbox="470 761 705 795">Дараах хүмүүс юм:</p> <p data-bbox="470 809 1014 881">(а) Тухайн байгууллагын бүх захирлууд буюу удирдах зөвлөлийн гишүүд; ба</p> <p data-bbox="470 894 1014 1110">(б) Уг тайлагнагч байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, хянах бүрэн эрх ба үүрэг хариуцлага бүхий бусад хүмүүс. Энэхүү шалгуурыг хангаж байх тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд дараах хүмүүс хамаарна:</p> <p data-bbox="530 1123 1014 1338">(i) Тайлагнагч байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, хянах бүрэн эрх ба үүрэг хариуцлага бүхий төрийн байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн байгаа тохиолдолд тэрхүү гишүүн;</p> <p data-bbox="530 1351 1014 1414">(ii) Тэрхүү гишүүний аливаа гол зөвлөгчид; ба</p> <p data-bbox="530 1428 1014 1652">(iii) Дээрх (а)-д нэгэнт хамрагдсан байхаас бусад тохиолдолд тухайн тайлагнагч байгууллагын дээд түвшний удирдлагын бүлэг, үүнд: уг байгууллагын гүйцэтгэх захирал буюу орон тооны дарга.</p>	20.4



ТАЙЛБАР ТОЛЬ

<b>түрээс</b>	Нэг төлбөр буюу цуврал төлбөрүүдийн хариуд түрээслүүлэгч нь тухайн хөрөнгийг тохиролцсон хугацаагаар ашиглах эрхийг түрээслэгчид шилжүүлдэг гэрээ.	13.8
<b>түрээсийн хугацаа</b>	Түрээслэгч нь тухайн хөрөнгийг түрээслэхээр гэрээ байгуулсан үл цуцлагдах хугацаа юм. Түрээслэгч нь хөрөнгийг үргэлжлүүлэн түрээслэх сонголтоо хэрэгжүүлнэ гэдэг нь уг түрээсийн хугацааны эхэнд үл үндэслэлтэйгээр тодорхой байх тохиолдолд нэмэлт төлбөр төлснөөр эсвэл төлөхгүйгээр үргэлжлүүлэн түрээслэх түүний энэхүү сонголтонд хамаарах цаашдын аливаа хугацаа нь түрээсийн хугацаанд хамаарна.	13.8
<b>хуулиар хүлээсэн үүрэг</b>	Дараах зүйлсээс үүсдэг үүрэг: (а) Гэрээ (түүний илэрхий буюу далд утгатай нөхцлөөр); (б) Хууль тогтоомж; эсвэл (в) Хуулийн бусад үйлчлэл.	19.18
<b>түрээслэгчийн зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшин</b>	Ижил төсөөтэй хөрөнгийн хувьд түрээслэгчийн төлөх ёстой байсан хүүний хувь хэмжээ, хэрэв үүнийг тодорхойлох боломжгүй бол тухайн хөрөнгийг худалдан авахад шаардлагатай мөнгө, санг ижил төсөөтэй хугацаанд ба адилтгах баталгаатайгаар зээлдэн авахын тулд уг түрээслэгчийн төлөх байсан тэрхүү түрээсийн үүссэн өдрөөрх хүүний хувь хэмжээ.	13.8
<b>өр төлбөр</b>	Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн уг байгууллагын одоогийн үүрэг бөгөөд түүнийг барагдуулсанаар эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөц тухайн байгууллагаас гарахаар хүлээгдэж байдаг.	1.7
<b>төлбөрийн чадварын эрсдэл</b>	Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгснөөр барагдуулах санхүүгийн өр төлбөртэй холбоотой үүргийг тухайн байгууллага биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл.	30.8

<b>Нэр томъёо зээл ба авлага</b>	<b>Тодорхойлолт</b>	<b>Байршил</b>
	<p>Идэвхитэй зах зээлд арилжаалдаггүй бөгөөд тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүдтэй доор дурдсанаас бусад, үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм:</p> <p>(а) Байгууллага нь нэн даруй эсвэл ойрын хугацаанд худалдан борлуулах санаа төлөвлөгөөтэй бөгөөд худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилах санхүүгийн хөрөнгө ба анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө;</p> <p>(б) Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгө; эсвэл</p> <p>(в) Зээлийн чанаргүйдлээс өөр бусад шалтгааны улмаас эзэмшигч нь өөрийн бараг бүх анхны хөрөнгө оруулалтыг нөхөж чадахааргүй болсон бөгөөд борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгө.</p>	29.10
<b>зээлийн өглөг</b>	<p>Зээлийн хэвийн нөхцөл бүхий богино хугацаат худалдааны өглөгөөс бусад санхүүгийн өр төлбөр.</p>	30.8
<b>зах зээлийн эрсдэл</b>	<p>Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь зах зээлийн үнийн өөрчлөлтийн улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл. Зах зээлийн эрсдэл нь валютын эрсдэл, хүүний түвшний эрсдэл, үнийн бусад эрсдэл гэсэн гурван төрлийн эрсдлээс бүрддэг.</p>	30.8

## ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
материаллаг байдал	Тухайн зүйлийн орхигдуулалт буюу буруу илэрхийлэлт нь уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн шийдвэр, хяналт үнэлгээнд дангаараа эсвэл хамтдаа нөлөө үзүүлж чадахаар байвал түүнийг материаллаг гэж үзнэ. Материаллаг байдал нь тухайн нөхцөл байдлын хүрээнд шүүн тунгаах уг орхигдуулалт буюу буруу илэрхийлэлтийн шинж төрөл ба хэмжээнээс хамаардаг. Тухайн зүйлийн хэмжээ эсвэл шинж төрөл нь, эсвэл хоёулаа нэгдсэн байдлаараа тодорхойлогч хүчин зүйл байж болох юм.	1.7

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>түрээсийн хамгийн бага төлбөрүүд</b>	<p>Дараах зүйлсийн хамтаар үйлчилгээний өртөг болгон төлөхийг түрээслэгчээс шаарддаг буюу шаардаж болох тухайн түрээсийн хугацааны турш дахь төлбөрүүд юм. Үүнд болзошгүй түрээсийг оруулахгүй боловч тохиромжтой тохиолдолд түрээслүүлэгчийн төлсөн бөгөөд түүнд нөхөн олгох татварууд хамаарна.</p> <p>(a) Түрээслэгчийн хувьд, тухайн түрээслэгч эсвэл түрээстэй холбоотой бусад талын баталгаа гаргасан аливаа дүнгүүд; ба</p> <p>(б) Түрээслүүлэгчийн хувьд, түрээслүүлэгчид дараах талуудын зүгээс баталгаа өгсөн аливаа үлдэх өртөг:</p> <p>(i) Түрээслэгч;</p> <p>(ii) Түрээстэй холбоотой бусад тал; эсвэл</p> <p>(iii) Түрээслүүлэгчтэй холбоогүй бөгөөд тухайн баталгааны дагуу хүлээх үүргийг барагдуулах санхүүгийн чадвартай, хараат бус гуравдагч этгээд.</p>	13.8

Гэвч түрээслэгч нь сонголт хэрэгжих боломжтой болох өдрөөрх бодит үнэ цэнээс хангалттай бага байхаар хүлээгдэж буй тийм үнээр тухайн хөрөнгийг худалдан авах сонголттой бөгөөд сонголтыг хэрэгжүүлнэ гэдэг нь уг түрээс үүссэн өдөр ул үндэслэлтэйгээр тодорхой бол түрээсийн хамгийн бага төлбөрүүд нь энэхүү худалдан авалтын опционыг хэрэгжүүлэхээр хүлээгдэж буй өдөр хүртэлх түрээсийн хугацааны туршид төлөх хамгийн бага төлбөрүүд болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төлбөрөөс бүрдэнэ.

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>мөнгөн зүйлс</b>	Эзэмшиж буй мөнгөн нэгжүүд, түүнчлэн тогтмол буюу тодорхойлж болох мөнгөн нэгжээр хүлээн авах хөрөнгө ба төлөх өр төлбөр.	4.10
<b>олон ажил олгогчийн хөтөлбөр</b>	Дараах үүрэг бүхий тогтоосон шимтгэлийн хөтөлбөр (улсын хөтөлбөр болон нийгмийн хамгааллын холимог хөтөлбөрөөс бусад) эсвэл тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр (улсын хөтөлбөрөөс бусад):	25.10
2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.	<p>(а) Ерөнхий хяналтан дор байдаггүй, өөр өөр байгууллагуудаас шимтгэл байдлаар оруулсан хөрөнгийг нэгтгэдэг; ба</p> <p>(б) Ажилтнууд нь аль байгууллагад ажиллаж байгаагаас үл хамааран тодорхойлсон, шимтгэл ба тэтгэмжийн түвшинд үндэслэн нэгээс олон байгууллагын ажилтнуудад тэтгэмжийг олгохын тулд тэдгээр хөрөнгийг ашигладаг.</p>	
<b>олон ажил олгогчийн хөтөлбөр</b>	Дараах үүрэг бүхий тогтоосон шимтгэлийн хөтөлбөр (улсын хөтөлбөрөөс бусад) эсвэл тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр (улсын хөтөлбөрөөс бусад):	39.8
2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.	<p>(а) Ерөнхий хяналтан дор байдаггүй, өөр өөр байгууллагуудаас шимтгэл байдлаар оруулсан хөрөнгийг нэгтгэдэг; ба</p> <p>(б) Ажилтнууд нь аль байгууллагад ажиллаж байгаагаас үл хамааран тодорхойлсон, шимтгэл ба тэтгэмжийн түвшинд үндэслэн нэгээс олон байгууллагын ажилтнуудад тэтгэмжийг олгохын тулд тэдгээр хөрөнгийг ашигладаг.</p>	
<b>олон-жилийн төсөв</b>	Нэгээс олон жилийн хувьд батлагдсан төсөв. Тухайн төсвийн хугацаанаас хойшхи тайлант үеүдийн хувьд хэвлэн нийтэлсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл нь үүнд хамаарахгүй.	24.7

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>хамтын байгууллага</b>	Өөрийн эзэд, гишүүд болон оролцогчдод ногдол ашиг, өртөг зардлын хямдруулалт болон бусад эдийн засгийн үр өгөөжийг шууд олгодог, хөрөнгө оруулагчийн өмчилдөг байгууллагаас бусад, байгууллага юм. Жишээлбэл; хамтарсан даатгалын компани, зээлийн холбоо болон хоршоо нь бүгд хамтын байгууллага болно.	40.5
<b>цэвэр хөрөнгө/өмч</b>	Бүх өр төлбөрийг хассаны дараа уг байгууллагын хөрөнгөнд үлдэх хувь оролцоо.	1.7
<b>тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)</b>	Тогтоосон тэтгэмжийн цэвэр хөрөнгийг тухайн хөтөлбөрийн хөрөнгийн дээд хязгаарт багтаан хязгаарласны аливаа үр нөлөөний хувьд тохируулагдсан уг хөтөлбөрийн дутагдал (эсвэл илүүдэл).	39.8
<b>тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүү</b>	Цаг хугацаа урсан өнгөрсний үр дүнд, тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-т тухайн тайлант үеийн туршид гарсан өөрчлөлт.	39.8
<b>гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалт</b>	Тухайн гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө/өмчид уг тайлагнагч байгууллагын эзэмших хувь оролцооны дүн.	4.10
<b>түрээсийн цэвэр хөрөнгө оруулалт</b>	Түрээсийн нуугдмал хүүний түвшнээр дискаунтчилсан түрээсийн нийт хөрөнгө оруулалт.	13.8
<b>цэвэр боломжит үнэ цэнэ</b>	Хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгох ба борлуулах, сольж арилжих буюу түгээн хуваарилахад шаардлагатай тооцоолсон өртөг, зардлыг хассан дүн.	12.9

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>үл цуцлагдах түрээс</b>	<p>Зөвхөн дараах тохиолдолд цуцалж болох түрээс:</p> <p>(а) Магадлал багатай зарим болзошгүй зүйлс гарч тохиолдсоноор;</p> <p>(б) Түрээслүүлэгчийн зөвшөөрснөөр;</p> <p>(в) Хэрэв түрээслэгч нь тухайн түрээслүүлэгчтэй уг хөрөнгө буюу адилтгах хөрөнгийн хувьд шинэ түрээсийн гэрээ байгуулсан бол; ба</p> <p>(г) Түрээс үүссэн өдрөөр ийм нэмэлт дүнг түрээслэгч төлснөөр тухайн түрээсийг үргэлжлүүлэх нь ул үндэслэлтэйгээр тодорхой болсон.</p>	13.8
<b>мөнгө бий болгодоггүй хөрөнгө</b>	Мөнгө бий болгогч хөрөнгөөс бусад хөрөнгө.	21.14
<b>хяналтын бус хувь оролцоо</b>	Хяналт тавигч байгууллагад шууд болон шууд бусаар үл хамаарах хяналтанд буй байгууллага дахь цэвэр хөрөнгө/өмч.	35.14
<b>арилжааны бус ажил гүйлгээ</b>	Арилжааны ажил гүйлгээнээс бусад ажил гүйлгээ юм. Арилжааны бус ажил гүйлгээнд, байгууллага хариуд нь ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлийг шууд өгөхгүйгээр нөгөө талаас үнэ цэнэт зүйлийг хүлээн авах, эсвэл хариуд нь ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлийг шууд авахгүйгээр нөгөө талд үнэ цэнэт зүйлийг өгдөг.	9.11
<b>мөнгөн бус зүйлс тодруулга</b>	<p>Мөнгөн зүйлсээс бусад зүйлс.</p> <p>Тодруулга нь санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулсан мэдээллээс гаднах бусад мэдээллийг агуулдаг. Тодруулга нь эдгээр тайланд толилуулсан зүйлсийн хүүрнэсэн тайлбар буюу дэлгэрэнгүй задаргаа, мөн эдгээр тайланд хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй зүйлсийн талаархи мэдээллээр хангадаг.</p>	10.7
		1.7

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>үүрэг хүлээлгэх үйл явдал</b>	Тухайн үүргийг барагдуулахаас өөр бодит сонголтгүй болоход уг байгууллагыг хүргэдэг, хуулиар хүлээсэн үүрэг эсвэл гэрээний бус үүрэг үүсгэдэг тийм үйл явдал.	19.18
<b>алдагдалтай гэрээ</b>	Гэрээний үүргийг биелүүлэхэд гарах, зайлсхийх боломжгүй зардал нь уг гэрээний дагуу авахаар хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхиас хэтрэх, хөрөнгийн болон үйлчилгээний арилжааны гэрээ.	19.18
<b>үндсэн үйл ажиллагаа</b>	Байгууллагын хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа.	2.8
<b>үйл ажиллагааны түрээс</b>	Санхүүгийн түрээсээс бусад түрээс.	13.8
<b>үйл ажиллагаа</b>	Бараа, үйлчилгээ нийлүүлэх замаар тухайн байгууллагын зорилтуудад хүрэхийн тулд эрхлэн явуулж, удирдан зохицуулах боломжтой нэгдмэл цогц үйл ажиллагаа ба холбогдох хөрөнгө, өр төлбөр.	40.5
<b>эзэмшигч (үйлчилгээний концессын хэлцэлд)</b>	Эрх бүхий этгээдийн зүгээс хөрөнгөнд тавих хяналтан дор төрийн үйлчилгээг үзүүлэхийн тулд уг үйлчилгээний концессын хөрөнгийг ашиглаж буй байгууллага.	32.8
<b>анхны төсөв</b>	Тухайн төсвийн хугацааны хувьд анх батлагдсан төсөв.	24.7
<b>ажилтны урт хугацааны бусад тэтгэмж</b>	Ажилтан холбогдох үйлчилгээг үзүүлсэн тайлант үеийн эцсээс хойш арван хоёр сарын дотор төлөгдөхгүй, ажилтны тэтгэмж (ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болон ажлаас халагдалтын тэтгэмжээс бусад).	25.10
2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.		



ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<p><b>ажилтны урт хугацааны бусад тэтгэмж</b></p>	<p>Ажилтны богино хугацааны тэтгэмж, ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болон ажлаас халагдалтын тэтгэмжээс бусад, ажилтны бүх тэтгэмж.</p>	39.8
<p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>		
<b>үнийн бусад эрсдэл</b>	<p>Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ буюу ирээдүйн мөнгөн гүйлгээ нь зах зээлийн үнийн өөрчлөлтийн (хүүний түвшний эрсдэл буюу валютын эрсдлээс үүссэнээс бусад өөрчлөлтийн) улмаас хэлбэлзэн өөрчлөгдөх эрсдэл бөгөөд тэдгээр өөрчлөлт нь тухайн санхүүгийн хэрэглүүр буюу түүний гаргагчид тусгайлан хамаарах хүчин зүйлсээс эсвэл зах зээлд арилжаалагдаж буй ижил төсөөтэй бүх санхүүгийн хэрэглүүрт нөлөөлөх хүчин зүйлсээс шалтгаалсан эсэхээс үл хамаарна.</p>	30.8
<b>хяналт</b>	<p>Байгууллагын үйл ажиллагааг хянах, санхүүгийн болон үйл ажиллагааны шийдвэрүүдийг хянах буюу мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх бүрэн эрх ба үүрэг хариуцлагатай байхыг хэлнэ.</p>	20.4
<b>эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө</b>	<p>Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд эсвэл захиргаа удирдлагын зорилгоор ашиглахын тулд эзэмшиж буй (эзний эсвэл санхүүгийн түрээсийн дагуу түрээслэгчийн эзэмшиж буй) үл хөдлөх хөрөнгө.</p>	16.7

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
эзэд	Энэ Стандартын зорилгын хувьд, тухайн үйл ажиллагаанд тоогоор илэрхийлж болох өмчлөлийн хувь оролцоо бүхий аливаа талыг хамруулахын тулд эзэд гэсэн ойлголтыг өргөн утгатайгаар ашигладаг. Үүнд: хөрөнгө оруулагчийн өмчилдөг байгууллагуудын өмчлөлийн хувь оролцооны эзэмшигчид болон хамтын байгууллагын эзэд, гишүүд буюу оролцогчид хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй.	40.5
<b>хамтын хэлэлцээрийн оролцогч тал</b>	Хамтын хэлэлцээрт оролцдог байгууллага бөгөөд энэ нь уг хэлэлцээрт тухайн байгууллага хамтын хяналттай эсэхээс үл хамаарна.	37.7
<b>хугацаа өнгөрсөн</b>	Гэрээний дагуу төлөх ёстой хугацаа болсон төлбөрийг нөгөө тал нь барагдуулаагүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн хугацаа өнгөрсөн гэнэ.	30.8
<b>өнгөрсөн үйлчилгээний зардал</b>	Тухайн тайлант үед ажил эрхлэлтийн дараах тэтгэмж буюу ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн нэвтрүүлэлт буюу өөрчлөлтийн үр дүнд ажилтны өмнөх тайлант үеүдэд үзүүлсэн үйлчилгээний хувьд төлөх тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэд гарсан өөрчлөлт. Өнгөрсөн үйлчилгээний зардал нь эерэг (тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх байдлаар тэтгэмжийг нэвтрүүлсэн буюу өөрчилсөн) эсвэл сөрөг (тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийг бууруулах байдлаар тэтгэмжийг нэвтрүүлсэн буюу өөрчилсөн) байж болно.	25.10
<b>хөтөлбөрийн хөрөнгө</b>	Дараах зүйлсээс бүрдэнэ: (а) Ажилтны урт хугацааны тэтгэмжийн сангийн эзэмшиж буй хөрөнгө; ба (б) Шалгуур хангах даатгалын гэрээнүүд.	25.10
2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.		

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<p><b>хөтөлбөрийн хөрөнгө</b></p> <p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>	<p>Дараах зүйлсээс бүрдэнэ:</p> <p>(а) Ажилтны урт хугацааны тэтгэмжийн сангийн эзэмшиж буй хөрөнгө; ба</p> <p>(б) Шалгуур хангах даатгалын гэрээнүүд.</p>	39.8
<p><b>ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр</b></p> <p>2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.</p>	<p>Байгууллага нь нэг буюу хэд хэдэн ажилтанд ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийг олгох албан буюу албан бус тохиролцоо.</p>	25.10
<p><b>ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн хөтөлбөр</b></p> <p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>	<p>Байгууллага нь нэг буюу хэд хэдэн ажилтанд ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийг олгох албан буюу албан бус тохиролцоо.</p>	39.8
<p><b>ажил эрхлэлтийн дараах тэтгэмж</b></p> <p>2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.</p>	<p>Ажилтны ажил эрхлэлт дуусгавар болсны дараа төлөгдөх ажилтны тэтгэмж (ажлаас халагдалтын тэтгэмжээс бусад).</p>	25.10
<p><b>ажил эрхлэлтийн дараах тэтгэмж</b></p> <p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>	<p>Ажилтны ажил эрхлэлт дуусгавар болсны дараа төлөгдөх тэтгэмж (ажлаас халагдалтын тэтгэмж ба ажилтны богино хугацааны тэтгэмжээс бусад).</p>	39.8
<b>бүрэн эрх</b>	<p>Өөр байгууллагын холбогдох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх одоогийн чадвар, боломжийг олгодог эрх.</p>	35.14

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<p><b>тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ</b></p> <p>2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.</p>	<p>Тухайн тайлант үед болон өмнөх тайлант үеүдэд ажилтны үзүүлсэн үйлчилгээний үр дүнд үүссэн үүргийг барагдуулахад шаардагдахаар хүлээгдэж буй ирээдүйн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ бөгөөд хөтөлбөрийн аливаа хөрөнгийг хасаагүй дүн байдаг.</p>	25.10
<p><b>тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэ</b></p> <p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>	<p>Тухайн тайлант үед болон өмнөх тайлант үеүдэд ажилтны үзүүлсэн үйлчилгээний үр дүнд үүссэн үүргийг барагдуулахад шаардагдахаар хүлээгдэж буй ирээдүйн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ бөгөөд хөтөлбөрийн аливаа хөрөнгийг хасаагүй дүн байдаг.</p>	39.8
<p><b>толилуулгын валют</b></p>	<p>Тухайн санхүүгийн тайланг толилуулдаг валют.</p>	4.10
<p><b>өмнөх тайлант үеийн алдаа</b></p>	<p>Үнэн зөв илэрхийлэх дараах мэдээллийг ашиглаагүй эсвэл буруу ашигласны улмаас тухайн байгууллагын нэг буюу хэд хэдэн тайлант үеүдийн санхүүгийн тайланд эдгээр мэдээллийг тусгахгүй орхигдуулалт болон буруу тусган илэрхийлэлт:</p> <p>(а) эдгээр тайлант үеүдийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөх үед бэлэн боломжтой байсан;</p> <p>(б) эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулах явцад олж авах ба түүнд харгалзан тусган оруулна гэж ул үндэслэлтэйгээр хүлээгдэж болох.</p> <p>Ийм алдаанд математик үйлдлийн алдаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхөд гаргасан алдаа, бодит байдалд хайнга хандалт буюу түүнийг буруу тайлбарлалт, түүнчлэн зальт ажиллагааны үр нөлөө хамаардаг.</p>	3.7

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
үндсэн хөрөнгө	<p>Дараах шинжтэй биет зүйлсийг хэлнэ. Үүнд:</p> <p>(а) Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглах, бусдад түрээслэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа; ба</p> <p>(б) Нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй.</p>	17.13
гүйцээх горимоор мөрдөлт	<p>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн үр нөлөөг тус тус гүйцээх горимоор мөрдөлт гэдэг нь харгалзан дараах зүйлсийг хэлнэ:</p> <p>(а) тухайн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилсөн өдрөөс хойш гарч тохиолдсон ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдалд уг шинэ бодлогыг мөрдөхийг;</p> <p>(б) нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн үр нөлөөг уг өөрчлөлтөөр нөлөө үзүүлэх тухайн тайлант үед болон ирээдүйн тайлант үеүдэд хүлээн зөвшөөрөхийг.</p>	3.7
хамгаалалтын эрх	<p>Тухайн эрхийг эзэмшиж буй талын хувь оролцоог хамгаалахад зориулагдсан эрх бөгөөд тэрхүү эрхийн хамаарах байгууллагын хувьд бүрэн эрхийг түүний эзэмшигчид олгодоггүй.</p>	35.14
нөөц	<p>Тодорхой бус хугацаа буюу дүн бүхий өр төлбөр.</p>	19.18

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>улсын секторын нэгдэл</b>	Тусдаа үйл ажиллагаануудыг улсын секторын нэг байгууллагад нэгтгэн оруулахыг хэлнэ.	40.5
<b>ерөнхий хяналтанд буй улсын секторын нэгдэл</b>	Хамаарах бүх байгууллагууд буюу үйл ажиллагааг уг улсын секторын нэгдлийн өмнө болон дараа тухайн нэг байгууллага эцэстээ хянадаг улсын секторын нэгдэл.	40.5
<b>буцаах эрхтэй хэрэглүүр</b>	Гаргагч талд уг хэрэглүүрийг буцаан өгч, мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнө авах эрхийг эзэмшигчдээ олгодог эсвэл ирээдүйд тодорхой бус үйл явдал гарч тохиолдох буюу хэрэглүүрийг эзэмшигч нас барах, тэтгэвэрт гарах үед тухайн гаргагч талд автоматаар буцаадаг санхүүгийн хэрэглүүр.	28.9
<b>шалгуур хангах хөрөнгө</b>	Түүнийг зориулалтын дагуу ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход нилээд их цаг хугацааг зайлшгүй шаарддаг хөрөнгө.	5.5

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<p><b>шалгуур хангах даатгалын гэрээ</b></p> <p>2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.</p>	<p>Тайлагнагч байгууллагын хувьд холбоотой тал (УСНББОУС 20-д тодорхойлсноор) биш байх тийм даатгагчтай байгуулсан даатгалын гэрээ<sup>1</sup> бөгөөд уг гэрээний орлого нь дараах шинжтэй байна:</p> <p>(а) Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу зөвхөн ажилтны тэтгэмжийг төлөх буюу санхүүжүүлэхэд ашиглагдах;</p> <p>(б) Тухайн тайлагнагч байгууллагын (дампуурлын үед ч гэсэн) зээлдүүлэгчдэд төлбөр хийхэд ашиглагдах боломжгүй бөгөөд доор дурдсан аль нэг тохиолдлоос бусад үед тайлагнагч байгууллагад буцаан олгогдохгүй:</p> <p>(i) Гэрээний орлого нь ажилтны холбогдох бүх тэтгэмжийн үүргийг барагдуулахад уг даатгалын гэрээний хувьд шаардлагагүй, илүүдэл хөрөнгийг илэрхийлэх; эсвэл</p> <p>(ii) Ажилтны тэтгэмжийг аль хэдийн төлсөн тайлагнагч байгууллагад тэрхүү төлбөрийг нөхөн олгохын тулд уг орлогыг тухайн байгууллагад буцаах.</p>	25.10

<sup>1</sup> Шалгуур хангах даатгалын гэрээ нь заавал даатгалын гэрээ байх албагүй юм (даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг үзнэ үү).

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<p><b>шалгуур хангах даатгалын гэрээ</b></p> <p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>	<p>Тайлагнагч байгууллагын хувьд холбоотой тал (УСНББОУС 20-д тодорхойлсноор) биш байх тийм даатгагчтай байгуулсан даатгалын гэрээ<sup>2</sup> бөгөөд уг гэрээний орлого нь дараах шинжтэй байна:</p> <p>(а) Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу зөвхөн ажилтны тэтгэмжийг төлөх буюу санхүүжүүлэхэд ашиглагдах;</p> <p>(б) Тухайн тайлагнагч байгууллагын (дампуурлын үед ч гэсэн) зээлдүүлэгчдэд төлбөр хийхэд ашиглагдах боломжгүй бөгөөд доор дурдсан аль нэг тохиолдлоос бусад үед тайлагнагч байгууллагад буцаан олгогдохгүй:</p> <p>(i) Гэрээний орлого нь ажилтны холбогдох бүх тэтгэмжийн үүргийг барагдуулахад уг даатгалын гэрээний хувьд шаардлагагүй, илүүдэл хөрөнгийг илэрхийлэх; эсвэл</p> <p>(ii) Ажилтны тэтгэмжийг аль хэдийн төлсөн тайлагнагч байгууллагад тэрхүү төлбөрийг нөхөн олгохын тулд уг орлогыг тухайн байгууллагад буцаах.</p>	<p>39.8</p>
<p><b>нөхөгдөх дүн (хөрөнгө буюу мөнгө бий болгогч нэгжийн)</b></p>	<p>Хөрөнгө буюу мөнгө бий болгогч нэгжийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр нь юм.</p>	<p>26.13</p>
<p><b>нөхөгдөх дүн (үндсэн хөрөнгийн)</b></p>	<p>Хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр дүн.</p>	<p>17.13</p>
<p><b>нөхөгдөх үйлчилгээний дүн</b></p>	<p>Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр нь юм.</p>	<p>21.14</p>

<sup>2</sup> Шалгуур хангах даатгалын гэрээ нь заавал даатгалын гэрээ байх албагүй юм (даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг үзнэ үү).



## ТАЙЛБАР ТОЛЬ

<b>ердийн нөхцлөөр худалдан авалт буюу борлуулалт</b>	Тухайн хамаарах зах зээл дэх зохицуулалт буюу тогтсон журмаар ерөнхийдөө тогтоодог цаг хугацааны дотор уг хөрөнгийг нийлүүлэхийг шаарддаг нөхцөл бүхий гэрээний дагуу санхүүгийн хөрөнгийг худалдан авах буюу борлуулах ажиллагаа.	29.10
<b>холбоотой тал</b>	<p>Хэрэв нэг тал нь (а) нөгөө талыг хянах, эсвэл (б) санхүүгийн болон үйл ажиллагааны шийдвэр гаргахад уг нөгөө талд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадвар боломжтой эсвэл тэрхүү холбоотой тал болох байгууллага ба нөгөө байгууллага нь нэг ерөнхий хяналтанд байдаг бол тэдгээр талуудыг холбоотой гэж үзнэ. Холбоотой талуудад дараах этгээд хамаарна:</p> <p>(а) Нэг болон хэд хэдэн дундын зуучлагчдаар дамжуулан уг тайлагнагч байгууллагыг шууд буюу шууд бусаар хянадаг эсвэл түүний хяналтанд байдаг байгууллагууд;</p> <p>(б) Хараат байгууллагууд (УСНББОУС 7, <i>Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт</i>-ыг үзнэ үү);</p> <p>(в) Тайлагнагч байгууллагад мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжийг олгох хувь оролцоог уг байгууллагад шууд буюу шууд бусаар өмчилдөг хувь хүмүүс болон ийм аливаа хувь хүний гэр бүлийн ойрын гишүүд;</p> <p>(г) Эрх бүхий албан тушаалтан ба уг эрх бүхий албан тушаалтны гэр бүлийн ойрын гишүүд; ба</p> <p>(д) Өмчлөлийн мэдэгдэхүйц хувь оролцоог нь дээрх (в) эсвэл (г)-д дурдсан аливаа хувь хүн шууд буюу шууд бусаар эзэмшдэг эсвэл ийм хувь хүн нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадвар боломжтой байдаг байгууллагууд.</p>	20.4

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>холбоотой талын ажил гүйлгээ</b>	Үнийг нэхэмжилсэн эсэхээс үл хамааран холбоотой талуудын хооронд хийгдэх нөөцийн буюу үүргийн шилжүүлэлт. Уг тайлагнагч байгууллагаас эсвэл өөрөө нэг хэсэг нь болох засгийн газраас зөвхөн эдийн засгийн хувьд хараат байгаагийн улмаас холбоотой тал болдог бусад аливаа байгууллагатай хийсэн ажил гүйлгээ нь холбоотой талын ажил гүйлгээнд хамаардаггүй.	20.4
<b>холбогдох үйл ажиллагаа</b>	Бусад байгууллага дахь оролцооноос тухайн байгууллагын хүлээн авах өгөөжийн шинж төрөл буюу дүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх уг боломжит хяналтанд буй байгууллагын үйл ажиллагаа.	35.14
<b>тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилт</b>	Дараах зүйлсээс бүрдэнэ: (а) Актуар олз, гарз; (б) Хөтөлбөрийн хөрөнгийн өгөөж, үүнд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүнд багтсан дүнг оруулахгүй; (в) Хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөнд гарсан аливаа өөрчлөлт, үүнд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүнд багтсан дүнг оруулахгүй.	39.8
<b>цуцлах эрх</b>	Шийдвэр гаргагчийн шийдвэр гаргах бүрэн эрхийг хасах эрх.	35.14
<b>эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал</b>	Удирдах зөвлөлийн гишүүний эсвэл өөр бусад байдлаар уг тайлагнагч байгууллагын ажилтны хувьд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үзүүлсэн үйлчилгээнийхээ төлөө тухайн тайлагнагч байгууллагаас тэрхүү эрх бүхий албан тушаалтны шууд буюу шууд бусаар авч буй аливаа төлбөр болон тэтгэмж.	20.4
<b>тайлангийн өдөр</b>	Тухайн санхүүгийн тайлангийн хамаарах тайлант үеийн сүүлчийн өдөр.	2.8
<b>судалгаа</b>	Шинжлэх ухааны буюу техникийн шинэ мэдлэг, ойлголт олж авах хэтийн зорилготойгоор хийгдэж буй бодит, төлөвлөгдсөн судлан шинжлэх үйл явц.	31.16

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>үлдэх өртөг (үндсэн хөрөнгө эсвэл биет бус хөрөнгийн)</b>	Хэрэв хөрөнгө ашиглагдаж, насжилттай болвол түүний ашиглалтын хугацааны эцэст хүлээгдэж буй тэрхүү нөхцөл байдалд хөрөнгийг данснаас хасахтай холбоотой тооцоолсон зардлыг хассаны дараа тухайн байгууллага уг хөрөнгийн данснаас хасалтаар одоо хүлээн авах тооцоолсон дүн.	17.13
<b>шилжүүлсэн хөрөнгөнд тавигдах хязгаарлалт</b>	Тухайн шилжүүлсэн хөрөнгийг ашиглаж болох зорилгыг хязгаарлах буюу чиглүүлэх боловч хэрэв тусгайлан заасны дагуу ашиглаагүй бол тэрхүү ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тухайн шилжүүлэгчид буцаан өгөх шаардлагатай гэж тусгайлан заадаггүй болзлууд.	23.7
<b>бүтцийн өөрчлөлт</b>	Удирдлага төлөвлөн хянаж байгаа бөгөөд дараах зүйлсийн аль нэгийг материаллагаар өөрчлөх хөтөлбөр юм:  (а) Байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ; эсвэл  (б) Тэдгээр үйл ажиллагааг эрхлэн явуулдаг арга маяг.	19.18
<b>үр дүнгийн байгууллага</b>	Нийлүүлэлтээр нэгдэж буй хоёр буюу хэд хэдэн үйл ажиллагаануудын үр дүн болох байгууллага.	40.5
<b>буцаах горимоор мөрдөлт</b>	Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг угаасаа мөрдөж байсан бол ямар байх байсан тийм байдлаар ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдалд тэрхүү бодлогыг даган мөрдөхийг хэлнэ.	3.7
<b>буцаан дахин тайлагналт</b>	Өмнөх тайлант үеийн алдаа угаасаа гараагүй бол ямар байх байсан тийм байдлаар санхүүгийн тайлангийн элементүүдийн дүнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тодруулгыг засварлахыг хэлнэ.	3.7

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<p><b>хөтөлбөрийн хөрөнгийн өгөөж</b></p> <p>2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.</p>	<p>Хөтөлбөрийн хөрөнгөөс бий болсон хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, бусад орлого, түүнчлэн уг хөтөлбөрийн хөрөнгийн хувьд хэрэгжсэн болон хэрэгжээгүй олз, гарзаас тэрхүү хөтөлбөрийг удирдан зохицуулах аливаа зардал (тогтоосон тэтгэмжийн үүргийг хэмжихийн тулд ашигласан актуар төсөөлөлд тусгаснаас бусад) ба уг сангийн өөрийн аливаа татварын өглөгийг хассан дүн.</p>	25.10
<p><b>хөтөлбөрийн хөрөнгийн өгөөж</b></p> <p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>	<p>Хөтөлбөрийн хөрөнгөөс бий болсон хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, бусад орлого, түүнчлэн уг хөтөлбөрийн хөрөнгийн хувьд хэрэгжсэн болон хэрэгжээгүй олз, гарз бөгөөд тэдгээрээс дараах зүйлсийг хассан дүн:</p> <p>(а) Хөтөлбөрийн хөрөнгийг удирдан зохицуулах аливаа зардал; ба</p> <p>(б) Тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийг хэмжихийн тулд ашигласан актуар төсөөлөлд багтсан татвараас бусад, уг сангийн өөрийн аливаа татварын өглөг.</p>	39.8
<p><b>орлого</b></p>	<p>Эздээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээ.</p>	1.7
<p><b>тусгай бүтэц бүхий байгууллагаас олсон орлого</b></p>	<p>Дараах орлого хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд: тогтмол болон тогтмол бус хураамж, хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, тусгай бүтэц бүхий байгууллага дахь хувь оролцоог дахин хэмжих буюу үл хүлээн зөвшөөрснөөс үүссэн олз буюу гарз, уг тусгай бүтэц бүхий байгууллагад хөрөнгө, өр төлбөрийг шилжүүлснээс үүссэн олз, гарз.</p>	38.7

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
сегмент	(а) Өөрийн зорилтуудад хүрэхдээ тухайн байгууллагын хийсэн өнгөрсөн гүйцэтгэлийг үнэлэх, ба (б) нөөцийн ирээдүйн хуваарилалтын талаар шийдвэр гаргах зорилгоор түүний хувьд санхүүгийн мэдээллийг тусад нь тайлагнахад тохиромжтой тухайн байгууллагын ялган тодорхойлж болох үйл ажиллагаа буюу үйл ажиллагаануудын бүлэг.	18.9
сегментийн нягтлан бодох бүртгэлийн бодлого	Нэгтгэсэн групп буюу байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахад мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүнчлэн сегментийн тайлагналд тусгайлан хамаарах тийм нягтлан бодох бүртгэлийн бодлого.	18.27
сегментийн хөрөнгө	<p>Сегмент өөрийн үндсэн үйл ажиллагаандаа ашигладаг болон тухайн сегментэд шууд хамааруулж болох эсвэл ул үндэслэлтэй сууриар түүнд хуваарилж болох үйл ажиллагааны хөрөнгө.</p> <p>Хэрэв сегментийн орлогод хүүний буюу ногдол ашгийн орлого хамаардаг бол түүний сегментийн хөрөнгөнд холбогдох авлага, зээл, хөрөнгө оруулалт буюу орлого бий болгох бусад хөрөнгө хамаарна.</p> <p>Орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах татвар төлөх үүргийг бүртгэн тайлагнах нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу хүлээн зөвшөөрдөг орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах хөрөнгүүд нь сегментийн хөрөнгөнд хамаарахгүй.</p> <p>Өмчийн аргаар тайлагнадаг хөрөнгө оруулалтын цэвэр ашгийг (алдагдлыг) сегментийн орлогод тусган оруулдаг зөвхөн тэр тохиолдолд ийм хөрөнгө оруулалт нь сегментийн хөрөнгөнд хамаарна. УСНББОУС 8, <i>Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо</i>-ны дагуу хувь тэнцүүлэн нэгтгэх аргаар тайлагнадаг уг хамтын хяналтанд буй байгууллагын үйл ажиллагааны хөрөнгөөс тухайн хамтарсан үйлдвэрийн хувь оруулагчид хамаарах</p>	18.27

## ТАЙЛБАР ТОЛЬ

хувь хэсэг нь сегментийн хөрөнгөнд хамаарна.

Тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайланд шууд суутган тооцох байдлаар тайлагнадаг, холбогдох хасагдуулгыг хассаны дараа, сегментийн хөрөнгийг тодорхойлно.

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
сегментийн зардал	<p>Сегментийн үндсэн үйл ажиллагаанаас үүссэн ба уг сегментэд шууд хамааруулж болох зардал, ул үндэслэлтэй сууриар сегментэд хуваарилж болох зардлын холбогдох хэсэг, үүн дотроо гаднын талуудад бараа, үйлчилгээ нийлүүлэхтэй холбоотой зардал, тухайн байгууллагын бусад сегментүүдтэй хийсэн ажил гүйлгээтэй холбоотой зардал юм. Сегментийн зардалд дараах зүйлс хамаарахгүй:</p> <ul style="list-style-type: none"> <li>(а) Сегментийн үйл ажиллагаа нь үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй байхаас бусад тохиолдолд хүүний зардал, үүн дотроо бусад сегментүүдээс авсан урьдчилгаа буюу зээлийн хувьд гаргасан хүүний зардал;</li> <li>(б) Сегментийн үйл ажиллагаа нь үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй байхаас бусад тохиолдолд хөрөнгө оруулалтын борлуулалтаас үүссэн гарз эсвэл өрийн барагдуулалтаас үүссэн гарз;</li> <li>(в) Хараат байгууллага, хамтарсан үйлдвэр болон өмчийн аргын дагуу тайлагнадаг бусад хөрөнгө оруулалтын цэвэр алдагдал буюу гарзаас тухайн байгууллагад хамаарах хэсэг;</li> <li>(г) Орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах татвар төлөх үүргийг бүртгэн тайлагнах нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу хүлээн зөвшөөрдөг орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах зардал; эсвэл</li> <li>(д) Ерөнхий удирдлагын зардал, төв оффисын зардал, түүнчлэн тухайн байгууллагын түвшинд гардаг бөгөөд бүхэлдээ уг байгууллагад хамаарах бусад зардал. Гэвч зарим үед сегментийн өмнөөс тухайн байгууллагын түвшинд зардал</li> </ul>	18.27

## ТАЙЛБАР ТОЛЬ

гардаг. Ийм зардал нь сегментийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд тухайн сегментэд шууд хамааруулах буюу үл үндэслэлтэй сууриар хуваарилж болох бол сегментийн зардал болно.

УСНББОУС 8-ын дагуу хувь тэнцүүлэн нэгтгэх аргаар тайлагнадаг уг хамтын хяналтанд буй байгууллагын зардлаас тухайн хамтарсан үйлдвэрийн хувь оруулагчид хамаарах хувь хэсэг нь сегментийн зардалд хамаарна.

Үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй сегментийн үйл ажиллагааны хувьд хүүний орлого ба хүүний зардлыг тухайн нэгтгэсэн буюу байгууллагын санхүүгийн тайланд цэвэр дүнгээр тусгадаг зөвхөн тийм тохиолдолд тэдгээрийг сегментийн тайлагналын зорилгоор нэг цэвэр дүн байдлаар тайлагнаж болно.



**Нэр томъёо**  
**сегментийн өр**  
**төлбөр**

**Тодорхойлолт**

Сегментийн үндсэн үйл ажиллагаанаас үүсдэг ба тухайн сегментэд шууд хамааруулж болох эсвэл ул үндэслэлтэй сууриар түүнд хуваарилж болох үйл ажиллагааны өр төлбөр юм.

Хэрэв сегментийн зардалд хүүний зардал хамаардаг бол түүний сегментийн өр төлбөрт холбогдох хүүтэй өр төлбөр хамаарна.

УСНББОУС 8-ын дагуу хувь тэнцүүлэн нэгтгэх аргаар тайлагнадаг уг хамтын хяналтанд буй байгууллагын өр төлбөрөөс тухайн хамтарсан үйлдвэрийн хувь оруулагчид хамаарах хувь хэсэг нь сегментийн өр төлбөрт хамаарна.

Орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах татвар төлөх үүргийг бүртгэн тайлагнах нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу хүлээн зөвшөөрдөг орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах өр төлбөрүүд нь сегментийн өр төлбөрт хамаарахгүй.

**Байршил**

18.27

<b>Нэр томъёо</b> <b>сегментийн орлого</b>	<b>Тодорхойлолт</b>	<b>Байршил</b>
	<p>Төсвийн буюу адилтгах хуваарилалт, буцалтгүй тусламж, шилжүүлэг, торгууль, хураамж, гаднын худалдан авагчдад хийсэн борлуулалт эсвэл тухайн байгууллагын бусад сегментүүдтэй хийсэн ажил гүйлгээнээс үүссэн эсэхээс үл хамааран сегментэд шууд хамаарах ба ул үндэслэлтэй сууриар сегментэд хуваарилж болох уг байгууллагын орлогын холбогдох хэсэг зэрэг байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан орлого юм. Сегментийн орлогод дараах зүйлс хамаарахгүй:</p> <p>(а) Сегментийн үйл ажиллагаа нь үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй байхаас бусад тохиолдолд хүүний буюу ногдол ашгийн орлого, үүн дотроо бусад сегментүүдэд олгосон урьдчилгаа буюу зээлийн хувьд олсон хүүний орлого; эсвэл</p> <p>(б) Сегментийн үйл ажиллагаа нь үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй байхаас бусад тохиолдолд хөрөнгө оруулалтын борлуулалтаас үүссэн олз эсвэл өрийн барагдуулалтаас үүссэн олз.</p> <p>Нэгтгэсэн буюу байгууллагын нийт орлогод тусган оруулдаг зөвхөн тийм тохиолдолд хараат байгууллага, хамтарсан үйлдвэр болон өмчийн аргын дагуу тайлагнадаг бусад хөрөнгө оруулалтын цэвэр ашиг (алдагдал)-аас тухайн байгууллагад хамаарах хэсэг нь сегментийн орлогод хамаарна.</p> <p>УСНББОУС 8-ын дагуу хувь тэнцүүлэн нэгтгэх аргаар тайлагнадаг уг хамтын хяналтанд буй байгууллагын орлогоос тухайн хамтарсан үйлдвэрийн хувь оруулагчид хамаарах хувь хэсэг нь сегментийн орлогод хамаарна.</p>	18.27

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
тусдаа санхүүгийн тайлан	Хяналтанд буй байгууллага, хамтарсан үйлдвэр, хараат байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-ийн дагуу өртгөөр нь, эсвэл УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт-д заасан өмчийн аргыг ашиглан тайлагнах сонголтыг энэхүү Стандартын шаардлагуудын дагуу хийж чадах тийм байгууллагын толилуулж буй санхүүгийн тайлан.	34.6
тусдаа бүтэц	Тусад нь тодорхойлж болох санхүүгийн бүтэц, үүн дотроо, хууль тогтоомжоор зөвшөөрсөн эрх зүйн этгээд буюу этгээдүүд, гэхдээ тэдгээр этгээд нь хуулийн этгээдийн эрхтэй эсэхээс үл хамаарна.	37.7
үйлчилгээний концессын хэлцэл	<p>Дараах нөхцөлтэйгээр эрх бүхий этгээд ба эзэмшигчийн хооронд байгуулсан заавал биелүүлэх хэлцэл:</p> <p>(а) Эзэмшигч нь эрх бүхий этгээдийн нэрийн өмнөөс төрийн үйлчилгээг үзүүлэхийн тулд уг үйлчилгээний концессын хөрөнгийг тодорхой хугацаанд ашиглах;</p> <p>(б) Үйлчилгээний концессын хэлцлийн хугацаанд түүний үзүүлсэн үйлчилгээний төлөө эзэмшигчид төлбөр олгох.</p>	32.8

ТАЙЛБАР ТОЛЬ

- үйлчилгээний  
концессын хөрөнгө** Үйлчилгээний концессын хэлцлийн дагуу төрийн үйлчилгээ үзүүлэхэд ашигладаг дараах хөрөнгө. Үүнд: 32.8
- (a) Эзэмшигчийн нийлүүлдэг доорх хөрөнгө:
    - (i) Эзэмшигч нь барьж байгуулсан, хөгжүүлсэн эсвэл гуравдагч талаас олж эзэмшсэн; эсвэл
    - (ii) Эзэмшигчид одоо байгаа хөрөнгө; эсвэл
  - (б) Эрх бүхий этгээдийн нийлүүлдэг доорх хөрөнгө:
    - (i) Эрх бүхий этгээдэд одоо байгаа хөрөнгө; эсвэл
    - (ii) Эрх бүхий этгээдэд одоо байгаа хөрөнгөнд хийсэн сайжруулалт.
- үйлчилгээний  
зардал** Дараах зүйлсээс бүрддэг: 39.8
- (a) Одоогийн үйлчилгээний зардал, энэ нь тухайн тайлант үед ажилтны үзүүлсэн үйлчилгээний үр дүн болох тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийн өсөлт юм;
  - (б) Өнгөрсөн үйлчилгээний зардал, энэ нь хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт (тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн нэвтрүүлэлт, хүчингүй болголт буюу өөрчлөлт) эсвэл цомхотгол (хөтөлбөрт хамрагдсан ажилтнуудын тоог тухайн байгууллага мэдэгдэхүйц цөөрүүлэлт)-ын үр дүнд ажилтны өмнөх тайлант үеүдэд үзүүлсэн үйлчилгээний хувьд төлөх тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнэд гарсан өөрчлөлт юм;
  - (в) Үүргийн барагдуулалтаар үүссэн аливаа олз, гарз.

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>барагдуулалт</b>	<p>Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу олгох бүх буюу зарим тэтгэмжийн хувьд хүлээх цаашдын бүх хуулийн эсвэл гэрээний бус үүргийг дуусгавар болгох ажил гүйлгээ, гэхдээ уг хөтөлбөрийн нөхцөлд заасан ба актуар төсөөлөлд харгалзан тусгасан, ажилтнуудад төлөх эсвэл тэдний өмнөөс төлөх тэтгэмжийн төлбөр үүнд хамаарахгүй.</p>	39.8
<b>ажилтны богино хугацааны тэтгэмж</b>	<p>Уг ажилтан холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор барагдуулахаар хүлээгдэж буй ажилтны тэтгэмж (ажлаас халагдалтын тэтгэмжээс бусад).</p>	25.10
<p>2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.</p>		
<b>ажилтны богино хугацааны тэтгэмж</b>	<p>Уг ажилтан холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор бүрэн барагдуулахаар хүлээгдэж буй ажилтны тэтгэмж (ажлаас халагдалтын тэтгэмжээс бусад).</p>	39.8
<p>2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.</p>		

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>мэдэгдэхүйц нөлөө (холбоотой талын ажил гүйлгээтэй холбоотойгоор)</b>	Байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт оролцох бүрэн эрхтэй боловч тэдгээр бодлогыг хянадаггүй байхыг хэлнэ. Мэдэгдэхүйц нөлөөг ихэвчлэн удирдах зөвлөл буюу адилтгах удирдах байгууллага дахь төлөөллөөр дамжуулан хэрэгжүүлдэг боловч мөн тухайлбал, дараах байдлаар хэд хэдэн арга замаар хэрэгжүүлж болно. Үүнд: (а) бодлого боловсруулах процессод оролцох, (б) эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох материаллаг ажил гүйлгээнд оролцох, (в) удирдах ажилтнуудыг харилцан солилцох, (г) техникийн мэдээллээс хамааралтай байлгах. Өмчлөлийн хувь оролцоо, дүрэм буюу гэрээгээр мэдэгдэхүйц нөлөөг тогтоож болох юм. Өмчлөлийн хувь оролцооны хувьд УСНББОУС 36-д заасан тодорхойлолтын дагуу мэдэгдэхүйц нөлөөг урьдчилан төсөөлдөг.	20.4
<b>мэдэгдэхүйц нөлөө (бусад байгууллагууд дахь хувь оролцоотой холбоотойгоор)</b>	Бусад байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт оролцох бүрэн эрхтэй боловч тэдгээр бодлогыг хянадаггүй буюу хамтран хянадаггүй байхыг хэлнэ.	36.8
<b>спот ханш</b>	Тэр даруй хийгдэх солилцоонд хамаарах валютын ханш.	4.10

## ТАЙЛБАР ТОЛЬ

<b>Нэр томъёо</b>	<b>Тодорхойлолт</b>	<b>Байршил</b>
<b>улсын хөтөлбөр</b> 2017 оны 12 дугаар сарын 31-нд буюу түүнээс өмнө эхлэх тайлант үеүд хүртэл мөрдөнө.	Хууль тогтоомжинд заасан, эдийн засгийн ангиллууд дахь бүх байгууллагуудад зориулсан, олон ажил олгогчийн хөтөлбөртэй адилаар үйл ажиллагаа явуулахаар хууль тогтоомжийн дагуу байгуулсан ба нийгмийн хамгааллын холимог хөтөлбөрөөс бусад хөтөлбөр.	25.10
<b>улсын хөтөлбөр</b> 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө.	Хууль тогтоомжинд заасан, эдийн засгийн ангиллууд дахь бүх байгууллагуудад зориулсан, олон ажил олгогчийн хөтөлбөртэй адилаар үйл ажиллагаа явуулахаар хууль тогтоомжийн дагуу байгуулсан хөтөлбөр.	39.8
<b>шилжүүлсэн хөрөнгийн болзол</b>	Тухайн тайлагнагч байгууллагын хувьд гаднын этгээд болох байгууллагууд уг шилжүүлсэн хөрөнгийг ашиглах талаар хууль, тогтоомж буюу заавал биелүүлэх хэлцэлд заасан нөхцлүүд.	23.7

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
<b>тусгай бүтэц бүхий байгууллага</b>	<p>Тусгай бүтэц бүхий байгууллага гэдэг нь:</p> <p>(а) Байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд захиргааны зохицуулалт буюу хууль тогтоомж нь ихэвчлэн голлох хүчин зүйл болдог байгууллагуудын хувьд тухайн байгууллагын хяналтыг тодорхойлоход заавал биелүүлэх хэлцэл чухал ач холбогдолтой бөгөөд холбогдох үйл ажиллагааг заавал биелүүлэх хэлцлийн арга замаар удирдан чиглүүлэх гэх мэтээр тэрхүү байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд уг захиргааны зохицуулалт буюу хууль тогтоомж нь голлох хүчин зүйл биш байхаар зохион байгуулсан байгууллага; эсвэл</p> <p>(б) Байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд саналын буюу адилтгах эрх нь ихэвчлэн голлох хүчин зүйл болдог байгууллагуудын хувьд аливаа саналын эрх нь зөвхөн захиргааны ажил үүрэгтэй холбоотой бөгөөд холбогдох үйл ажиллагааг заавал биелүүлэх хэлцлийн арга замаар удирдан чиглүүлдэг гэх мэтээр тэрхүү байгууллагыг хэн хянаж буй эсэхийг шийдвэрлэхэд уг саналын буюу адилтгах эрх нь голлох хүчин зүйл биш байхаар зохион байгуулсан байгууллага.</p>	38.7
<b>татварын зарлага</b>	Бусад этгээдэд олдох боломжгүй хөнгөлөлтийг зарим татвар төлөгчдөд олгодог татварын хуулийн хөнгөлөлттэй нөхцлүүд.	23.7
<b>татвар ногдох үйл явдал</b>	Засгийн газар, хууль тогтоогч байгууллага буюу бусад эрх бүхий байгууллагуудаас татвар ногдох зүйл гэж тодорхойлсон үйл явдал.	23.7



ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
татвар	Засгийн газарт орлого оруулахын тулд тогтоосон бөгөөд хууль тогтоомжийн дагуу улсын секторын байгууллагуудад албан журмаар төлсөн эсвэл төлөх эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи. Хууль зөрчсөний улмаас ногдуулж буй торгууль буюу бусад шийтгэвэр нь татварт хамаарахгүй.	23.7
<b>ажлаас халагдалтын тэтгэмж</b>	<p>Дараах зүйлсийн аль нэгний үр дүнд олгох ажилтны тэтгэмжийг хэлнэ:</p> <p>(а) Тэтгэвэрт гарах хэвийн хугацаанаас өмнө ажилтны ажил эрхлэлтийг дуусгавар болгох тухайн байгууллагын шийдвэр; эсвэл</p> <p>(б) Тэдгээр тэтгэмжийн хариуд сайн дураар ажлаас гарахыг зөвшөөрсөн ажилтны шийдвэр.</p>	25.10
<b>ажлаас халагдалтын тэтгэмж</b>	<p>Дараах зүйлсийн аль нэгний үр дүнд ажилтны ажил эрхлэлтийг дуусгавар болгосны хариуд түүнд олгох тэтгэмжийг хэлнэ:</p> <p>(а) Тэтгэвэрт гарах хэвийн хугацаанаас өмнө ажилтны ажил эрхлэлтийг дуусгавар болгох тухайн байгууллагын шийдвэр; эсвэл</p> <p>(б) Ажил эрхлэлтийг дуусгавар болгосны хариуд тэтгэмж олгох саналыг хүлээн зөвшөөрсөн ажилтны шийдвэр.</p>	39.8
<b>ажил гүйлгээний зардал</b>	Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн олж эзэмшилт, гаргалт, данснаас хасалтанд шууд хамаарах өсөн нэмэгдэх зардал ([УСНББОУС 29]-ийн Хавсралт А-гийн МЗУ26-р параграфыг үзнэ үү). Өсөн нэмэгдэх зардал нь хэрэв байгууллага тухайн санхүүгийн хэрэглүүрийг олж эзэмшээгүй, гаргаагүй, данснаас хасаагүй бол гарахгүй байсан тийм зардал байдаг.	29.10

ТАЙЛБАР ТОЛЬ

Нэр томъёо	Тодорхойлолт	Байршил
шилжүүлэг	Татвараас бусад, арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн орлогын гүйлгээ.	23.7
урьдчилж орсон санхүүгийн орлого	Дараах хоёр дүнгийн хоорондох зөрүү юм: (а) Түрээсийн нийт хөрөнгө оруулалт; ба (б) Түрээсийн цэвэр хөрөнгө оруулалт.	13.8
баталгаагүй, үлдэх өртөг	Уг үлдэх өртгийг олж авах эсэх талаар түрээслүүлэгчийн зүгээс баталгаа гаргаагүй эсвэл түрээслүүлэгчтэй холбоотой талаас зөвхөн баталгаа гаргасан тухайн түрээслэсэн хөрөнгийн үлдэх өртгийн тэрхүү хэсэг.	13.8
ашиглалтын хугацаа (түрээсийн)	Тухайн хөрөнгөнд агуулагдаж буй эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг түрээсийн хугацааны эхлэлийн өдрөөс уг байгууллага зарцуулахаар хүлээгдэж буй тооцоолсон үлдэх хугацаа бөгөөд үүнийг тэрхүү түрээсийн хугацаагаар хязгаарлахгүй.	13.8
ашиглалтын хугацаа (мөнгө бий болгодоггүй хөрөнгийн)	Ашиглалтын хугацаа гэдэг нь: (а) тухайн байгууллагад уг хөрөнгө ашиглагдахаар хүлээгдэж буй хугацаа; эсвэл (б) байгууллага нь тухайн хөрөнгөөс олж авахаар хүлээж буй бүтээгдэхүүн буюу түүнтэй адилтгах нэгжүүдийн тоо хэмжээ.	21.14
ашиглалтын хугацаа (үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн)	Ашиглалтын хугацаа гэдэг нь: (а) Байгууллагад уг хөрөнгө ашиглагдах боломжтой байхаар хүлээгдэж буй хугацаа; эсвэл (б) Байгууллага тухайн хөрөнгөөс олж авахаар хүлээгдэж буй бүтээгдэхүүн буюу түүнтэй ижилт төсөөтэй нэгжүүдийн тоо хэмжээ.	17.13

ТАЙЛБАР ТОЛЬ

<b>Нэр томъёо</b>	<b>Тодорхойлолт</b>	<b>Байршил</b>
<b>мөнгө бий болгогч хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ</b>	Тухайн хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас болон түүний ашиглалтын хугацааны эцэст данснаас хасалтаас бий болохоор хүлээгдэж буй тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ.	26.13
<b>мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ</b>	Тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнэ.	21.14
<b>ажилтны баталгаат тэтгэмж</b>	Ирээдүйн ажил эрхлэлтээс үл хамаарах ажилтны тэтгэмж.	25.10

## 2018 оны 01 дүгээр сарын 31-ний байдлаар гаргасан байгаа Аккруэл суурьт УСНББОУС-ууд

### Хүснэгт А: 2018 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй УСНББОУС-ын жагсаалт

2018 оны Гарын авлагад бүх УСНББОУС-ыг тусгасан. УСНББОУС-ууд нь хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт оруулсан текстийг тусган харуулдаг. УСНББОУС нь хараахан хүчин төгөлдөр болоогүй байгаа параграфуудыг агуулсан тохиолдолд тэдгээр параграфыг жагсаан илэрхийлсэн. Нэмэлт өөрчлөлт оруулсан параграфын хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө мөрдөхийг сайшаан дэмждэг.

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Толилуулга (хянан засварласан)	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01	153М	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 2, Мөнгөн Гүйлгээний Тайлан	2000 оны 5-р сар	2001 оны 7-р сарын 01				
УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01				

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө	2008 оны 4-р сар	2010 оны 01-р сарын 01				
УСНББОУС 5, Зээлийн Өртөг	2000 оны 5-р сар	2001 оны 7-р сарын 01				
УСНББОУС 9, Арилжааны Ажил Гүйлгээний Орлого	2001 оны 7-р сар	2002 оны 7-р сарын 01				
УСНББОУС 10, Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал	2001 оны 7-р сар	2002 оны 7-р сарын 01	22	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			38Д	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 11, Барилгын Гэрээ	2001 оны 7-р сар	2002 оны 7-р сарын 01				
УСНББОУС 12, Бараа Материал	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01				
УСНББОУС 13, Түрээс (хянан засварласан)	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01				

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 14, Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01	31	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			32Д	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 16, Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө (хянан засварласан)	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01	18А	Шинэ	УСНББОУС 40	2016
			87	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			90	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			101Д	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 16, Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө (хянан засварласан)	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01	18А	Шинэ	УСНББОУС 40	2016
			60	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01	88	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			107П	Шинэ	УСНББОУС 40	2016

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 18, Семментийн Тайлагнал	2002 оны 6-р сар	2003 оны 7-р сарын 01	34	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			37	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			76Д	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 19, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө	2002 оны 10-р сар	2004 оны 01-р сарын 01	4А	Шинэ	УСНББОУС 40	2016
			111Ж	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 20, Холбоотой Талуудын Тодруулга	2002 оны 10-р сар	2004 оны 01-р сарын 01				
УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт	2004 оны 12-р сар	2006 оны 01-р сарын 01	14	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			20А	Шинэ	УСНББОУС 40	2016
			82И	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 22, Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01				

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 23, Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)	2006 оны 12-р сар	2008 оны 6-р сарын 30	1	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			124Д	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 24, Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга	2006 оны 12-р сар	2009 оны 01-р сарын 01				



УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт	2008 оны 02-р сар		2009 оны 4-р сарын 01		УСНББОУС 40	2016
	2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016		
	7	Хассан	УСНББОУС 40	2016		
	18А	Шинэ	УСНББОУС 40	2016		
	20А	Шинэ	УСНББОУС 40	2016		
	23	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016		
	71	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016		
	76	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016		
	88	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016		
	90А	Шинэ	УСНББОУС 40	2016		
	90Б	Шинэ	УСНББОУС 40	2016		
	90В	Шинэ	УСНББОУС 40	2016		
	90Г	Шинэ	УСНББОУС 40	2016		
	90Д	Шинэ	УСНББОУС 40	2016		
	90Е	Шинэ	УСНББОУС 40	2016		
	90Ж	Шинэ	УСНББОУС 40	2016		
90И	Шинэ	УСНББОУС 40	2016			
90К	Шинэ	УСНББОУС 40	2016			
90Л	Шинэ	УСНББОУС 40	2016			
90М	Шинэ	УСНББОУС 40	2016			
90Н	Шинэ	УСНББОУС 40	2016			
90О	Шинэ	УСНББОУС 40	2016			

90П	Шинэ	УСНББОУС 40	2016
90Р	Шинэ	УСНББОУС 40	2016
91	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
92	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
96	Хассан	УСНББОУС 40	2016
97А	Шинэ	УСНББОУС 40	2016
97Б	Шинэ	УСНББОУС 40	2016
97В	Шинэ	УСНББОУС 40	2016
97Г	Шинэ	УСНББОУС 40	2016
97Д	Шинэ	УСНББОУС 40	2016
97Е	Шинэ	УСНББОУС 40	2016
97Ж	Шинэ	УСНББОУС 40	2016
97И	Шинэ	УСНББОУС 40	2016
98	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
99	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
100	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
102	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
103	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
106	Нэмэлт	УСНББОУС 40	2016

		өөрчлөлт		
107	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016	
108	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016	
110	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016	
111	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016	
111А	Шинэ	УСНББОУС 40	2016	
111Б	Шинэ	УСНББОУС 40	2016	
120	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016	
122	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016	
122А	Шинэ	УСНББОУС 40	2016	
123	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016	
124	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016	
125	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016	
126Л	Шинэ	УСНББОУС 40	2016	

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 27, Хөдөө Аж Ахуй	2009 оны 12-р сар	2011 оны 4-р сарын 01	48	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга	2010 оны 01-р сар	2013 оны 01-р сарын 01	56E	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт	2010 оны 01-р сар	2013 оны 01-р сарын 01	2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			125Ж	Шинэ	УСНББОУС 40	2016
			МЗУ35	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			МЗУ131	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			Б4	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга	2010 оны 01-р сар	2013 оны 01-р сарын 01				

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө	2010 оны 01-р сар	2011 оны 4-р сарын 01	3	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			18	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			18А	Шинэ	УСНББОУС 40	2016
			24	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			26А	Шинэ	УСНББОУС 40	2016
			39А	Шинэ	УСНББОУС 40	2016
			39Б	Шинэ	УСНББОУС 40	2016
			39В	Шинэ	УСНББОУС 40	2016
			39Г	Шинэ	УСНББОУС 40	2016
			39Д	Шинэ	УСНББОУС 40	2016
			40	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			41	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016

			66	Нэмэлт еөрчлөлт	УСНББОУС 40	2016
			67	Нэмэлт еөрчлөлт	УСНББОУС 40	2016
			93А	Шинэ	УСНББОУС 40	2016
			110	Нэмэлт еөрчлөлт	УСНББОУС 40	2016
			114А	Шинэ	УСНББОУС 40	2016
			117	Нэмэлт еөрчлөлт	УСНББОУС 40	2016
			132К	Шинэ	УСНББОУС 40	2016

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл	2011 оны 10-р сар	2014 оны 01-р сарын 01				
			62А	Шинэ	УСНББОУС 40	2016
			62Б	Шинэ	УСНББОУС 40	2016
			62В	Шинэ	УСНББОУС 40	2016
			86	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх	2015 оны 01-р сар	2017 оны 01-р сарын 01	129	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			130	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			132	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			154В	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан	2015 оны 01-р сар	2017 оны 01-р сарын 01				

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан	2015 оны 01-р сар	2017 оны 01-р сарын 01	4	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			40	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			52	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			55А	Шинэ	УСНББОУС 40	2016
			56	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			57	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			63	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			79В	Шинэ	УСНББОУС 40	2016
			79Г	Шинэ	УСНББОУС 40	2016



УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт	2015 оны 01-р сар	2017 оны 01-р сарын 01	26	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			31	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			33	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			34А	Шинэ	УСНББОУС 40	2016
			34Б	Шинэ	УСНББОУС 40	2016
			51Б	Шинэ	УСНББОУС 40	2016
			51В	Шинэ	УСНББОУС 40	2016

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Хараахан хүчин төгөлдөр болоогүй параграфууд			
			Хүчин төгөлдөр болоогүй параграф	Хэрхэн өөрчилсөн	Нэмэлт өөрчлөлтийн эх сурвалж	Эх параграф бүхий гарын авлага
УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр	2015 оны 01-р сар	2017 оны 01-р сарын 01	24А	Шинэ	УСНББОУС 40	2016
			32	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40	2016
			41А	Шинэ	УСНББОУС 40	2016
			42Б	Шинэ	УСНББОУС 40	2016
			42В	Шинэ	УСНББОУС 40	2016
			МЗУ33А	Шинэ	УСНББОУС 40	2016
			МЗУ33Б	Шинэ	УСНББОУС 40	2016
МЗУ33В	Шинэ	УСНББОУС 40	2016			
			МЗУ33Г	Шинэ	УСНББОУС 40	2016
УСНББОУС 38, Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга	2015 оны 01-р сар	2017 оны 01-р сарын 01				
УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж	2016 оны 7-р сар	2018 оны 01-р сарын 01				

**Хүснэгт Б: 2018 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар хараахан хараахан хүчин төгөлдөр болоогүй  
УСНББОУС-ын жагсаалт**

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Нөлөөлсөн бусад УСНББОУС-ууд
УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл	2017 оны 01-р сар	2019 оны 01-р сарын 01	УСНББОУС 1 УСНББОУС 10 УСНББОУС 14 УСНББОУС 16 УСНББОУС 17 УСНББОУС 18 УСНББОУС 19 УСНББОУС 21 УСНББОУС 23 УСНББОУС 26 УСНББОУС 27 УСНББОУС 29 УСНББОУС 31 УСНББОУС 33 УСНББОУС 35 УСНББОУС 36 УСНББОУС 37

## Хүснэгт В: 2017 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар хүчингүй болсон УСНББОУС-ын жагсаалт

Орлуулсан ба/буюу хүчингүй болгосноор цаашид мөрдөгдөхгүй УСНББОУС-уудын жагсаалтыг доорх Хүснэгтэнд харуулав.

УСНББОУС	Гаргасан	Хүчин төгөлдөр болсон анхны хугацаа	Шалтгаан ба хүчин төгөлдөр бус болсон огноо
УСНББОУС 6, Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан (хянан засварласан)	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01	2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдээс хойш УСНББОУС 6-г УСНББОУС 34 ба УСНББОУС 35 орлоно.
УСНББОУС 7, Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт (хянан засварласан)	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01	2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдээс хойш УСНББОУС 7-г УСНББОУС 36 орлоно.
УСНББОУС 8, Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо (хянан засварласан)	2006 оны 12-р сар	2008 оны 01-р сарын 01	2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдээс хойш УСНББОУС 8-ыг УСНББОУС 37 орлоно.
УСНББОУС 15, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга ба Толилуулга	2001 оны 12-р сар	2003 оны 01-р сарын 01	2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдээс хойш УСНББОУС 15-ыг УСНББОУС 28-30 орлоно.
УСНББОУС 25, Ажилтны Тэтгэмж	2008 оны 02-р сар	2011 оны 01-р сарын 01	2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдээс хойш УСНББОУС 25-ыг УСНББОУС 39 орлоно.



# УСНББОУС

